

АРБ★ТЫН ЖҮҮЖДҮҮД



АНАТОЛИЙ РЫБАНОВ

Анатолий Рыбаков

Арбатын хүүхдүүд

Гурамсан роман

Өмнөх үг

Оросын нэрт зохиолч Анатолий Рыбаковын зохиол бүр өөрийн гэсэн өнгө аяс, өвөрмөц шинж чанарыг агуулсан байдаг. Түүний “Арбатын хүүхдүүд” роман нь Оросын (1934-1943) хэлмэгдсэн сэхээтэн залуучуудын эмгэнэлт хувь заяаг олон түмэнд ил гарган харуулж, хэдэн арван жил нууцлагдмал байсан чулуун хэрмэн ханыг нурааж чадсанаараа онцлог юм.

Анатолий Рыбаковын хувьд “Арбатын хүүхдүүд” роман нь түүний хувь заяаны түүх юм. Тэрээр сурвалжлагчдад өгсөн нэгэн ярилцлагандаа: “Зохиолын гол дүр болох Саша Панкратовын тухайд хэлэх хэдэн тайлбар байна. “Арбатын хүүхдүүд” нь амьдралын намтарчилсан түүх юм. Би юу хэлэх гээд байна вэ, гэхээр зохиолын гол баатрын амьдралд тохиолдож байгаа үйл явдлууд нь миний амьдралд тохиолдсон зүйлтэй таарч байгаа юм” гэжээ. Ийнхүү зохиолч, гол баатрынхаа дүрээр өөрт тохиолдсон бодит үйл явдал, сэтгэлийн хөдлөл, шаналал, азгүйдэл, эмгэнэлээ илэрхийлэн гаргасан байдаг.

Арбат[1] нь зохиолын хэд хэдэн зангилаа болж байгаа ч гол утга санааг төлөөлөхгүй нь мэдээж. Харин зохиолын гол зангилаа нь түүх юм. Романы гол зорилгыг зохиолч: “Энэ романд тухайн цаг үеийн баримтат үйл явдлыг хүүрнэн өгүүлэх нь хамгаас чухал байлаа: нэг талаас Москва хотын шинэчлэгдэн өөрчлөгдөх амьдралын хэв маяг, дүр төрх, нөгөө талаас аймшиггүйгээр эдлэх эрх ямба, төрийн эрхийг гартаа авах хязгааргүй шунал, улс төрийн гажуудлыг харуулахыг хүсч байлаа” хэмээн тодорхойлсон байдаг.

Хэдийгээр романы гол баатрууд энгийн хүмүүс байдаг ч, Арбат нь тэдний оршин суугаа орчин юм. Хүмүүс энэ ертөнц дээр оршин тогтнож байгаа цагт тэдний амьдрал хоорондоо салшгүй холбоотой байдаг...

ТЭРГҮҮН БОТЪ

АРБАТЫН ХҮҮХДҮҮД

Нэгдүгээр хэсэг

1

Хуучин Никольский, Денежный гэдэг байсан хоёр гудмыг одоо Плотников хөндлөн гудам, Весниний гудамж гэх болж Арбатын хамгийн том байшин энэ хоёрын дунд байх бөлгөө. Найман давхар гурван өндөр байшин бөөр бөөрөөрөө нийлэн зэргэцэх агаад эхний байшингийн нүүрэн талыг цагаан шаазангаар бүржээ. Тэнд “Торон тууз”, “Ээрүүг анагаах”, “Арьс өнгө, шээсний сүвний өвчнүүд” гэсэн хаяг өлгөөтэй харагдана. Гөлмөн төмрөөр захалсан намхан аркууд гурван байшингийн хоорондох харанхуй ангал шиг хоёр довжоо талбайг холбоно.

Саша Панкратов гэрээсээ гарч солгой гар тийшээ, Смоленскийн талбай руу эргэв. “Арбатский Арс” кино театрын дэргэдүүр охид хэдийн хос хосоороо холхиж байлаа. Эд нар бол Арбатын охид, бас Дорогомиловоос ч, Плющихаас ч байгаа. Пальтоныхоо захыг хайш яйшхан босгож, уруулаа будаж, сормуусаа нумлан сэртийлгээд хүзүүндээ эрээн алчуур орхиж, харц нь хүсэж хүлээсэн янзтай буй нь намрын Арбатын хээнцэрлэл авай. Кино дуусахад үзэгчид хашаан дундуур явсаар нарийхан хаалгаар гудамж руу сандран гарахуйяа тэнд энэ орчмынхоо “эзэн хаад” болсон хэсэг багачуул хэзээний түлхэлдэн байлаа.

Арбатын өдөр өндөрлөж байгаа нь энэ. Хөсөг явах хэсгийг нь асфальталсан боловч трамвайны замын дундуур чулуу арзайлдсан өргөн замаар зөвлөлтийн “ГАЗ”, “АМО” хэмээх анхны машинууд хуучин сүйх тэрэгнүүдийг ардаа орхин давхилдана. Трамвай паркаасаа нэг, эсвэл хоёр вагон чирч хөдлөх болсон нь их хотын унааны хэрэгцээг хангах гэсэн найдлагагүй оролдлого ажээ. Харин газар доогуур метроны эхний ээлжийг хэдийн барьж эхэлснийг гэрчлэн Смоленскийн талбай дээр модон цамхаг сэргийжээ.

Хөдөөгийн бүдүүн ширхэгтэй ноосоор нэхсэн цамцтай, нэлээд шанаархуу, бор нүдтэй, тал нутгийн бүсгүй Катя “Каучук” заводын клубийн дэргэд Охидын талбай дээр Сашаг хүлээж байв. Түүнээс дарс ханхлах ажээ.

—Бид нар улаан дарс уусан юм. Чамд чинь баяр хамаагүй юм уу?

—Ямар баяр?

—Яагаав... Покровын баяр.

—Аа...

—“Аа” гэнэ шүү.

—Хаашаа явах вэ?

—Хаачдаг юм бэ... Манай найзынх руу.

—Юу авахав?

–Тэнд зууш бий. Архи ав.

Согтуу хөлчүү хүний яриа, ая хөг барагтайхан дуу, гармонь хөгжим, эгшигт хайрцгийн аялгуу сонсдох ажилчдын хуучин хуарангийн дэргэдүүр Саввины их гудмаар уруудаж, дараа нь үйлдвэрийн модон хашааны хоорондуур нарийхан гудаагаар доошилсоор сайхь хоёр голын эргийн өргөн зам дээр гарч ирлээ. Зүүн талд Свердлов, Ливерсийн фабрикуудын өргөн цонхнууд, баруун талд нь Москва гол, урд талд нь Новодевичийн хийдийн хэрэм, Тойргийн төмөр замын гүүрийн төмөр хашлаганууд цаашлаад намаг, нуга, Кочки, Лужники гээд л... үргэлжилнэ.

–Чи намайг хааш нь аваачих нь вэ? гэж Саша асуув.

–Хааш нь, хааш нь... явж л бай, гуйлгачин хүнд хол газар гэж байхгүй.

Саша бүсгүйг мөрөөр нь тэвэрсэнд цаадах нь гарыг нь зайлуулах гэж оролдов.

–Тэвчзэнэ л дээ.

Саша бүсгүйг мөрөөр нь улам чанга тэврэв.

–Битгий дүрсгүйт.

Шавардлагагүй дөрвөн давхар байшин онцгойдуухан байх ажээ. Тэр хоёр энэ байшингийн тоо томшгүй олон хаалгатай, бүдэгхэн гэрэлтэй урт хонгилоор явж явж сүүлчийн хаалганы дэргэд ирмэгц Катя,

–Марусягийн найз нь байгаа... Чи элдэв юм битгий асуугаарай гэв.

Буйдан дээр нэгэн эр цаашаа харан хэвтэж байв. Цонхны дэргэд сууж байсан арав, арван нэг орчим насны хүү, охин хоёр үүд рүү харснаа Катятай мэндлэв. Өрөөний буланд гарын угаагуурын зэргэлдээ байгаа авсаархан ширээний дэргэд нүдэнд дулаахан дөлгөөн царайтай, насаар Катягаас олон эгч давжаа нэгэн хүүхэн юм хийж харагдана. Энэ нь Маруся аж.

Тэрээр гараа арчин хормогчоо тайлах зуур,

–Бид ч бүр хүлээж цөхөрлөө шүү, нэг газар наргицгаагаад ирэхгүй нь л гэж бодлоо...
Василий Петрович, босоорой, зочид ирсэн шүү гэв.

Бүрзгэр царайтай туранхай эр өндийж шингэхэн үсээ илснээ нойроо сэргээн нүүрээ шувтрав. Цамцных нь зах үнгэгдэн үрчийж, зангианых нь уяа нэлээд суларчээ. Маруся,

–Бялуу маань хатчихлаа хэмээн ширээн дээр байгаа хөх тарианы гурилаар хийсэн бялууг бүтээсэн алчуурыг авч, – Энэ нь шар буурцагтай, энэ нь төмстэй, тэр нь байцаатай гэж зааснаа, –Тома, таваг аваад аль гэв.

Охин тавагнууд авчирч ширээн дээр тавилаа. Катя хантаазаа тайлан шүүгээнээс хутга сэрээ авч тэр даруй ширээ засалцаж эхлэх нь юу хаа байдгийг андахгүй, эднийд нэг бус ирсэн нь

илт. Тэрээр,

–Өрөөгөө янзал! хэмээн Марусяд тушаангуй хэлэхэд цаадах нь сандал дээр тохсон хувцас хунарыг авах зуур биеэ өмөөрөх мэт,

–Үдийн хоолоо идчихээд унтаад өгчээ, бас энэ хүүхдүүд бөөн цаас хяргачихаж. Витя, цаасаа түү гэж өгүүлэв.

Хөвгүүн шалан дээгүүр мөлхөн цаасныхаа хяргадсыг түүлээ.

Василий Петрович угаагуурт нүүр гараа угаагаад зангиагаа чангалав.

Маруся хоёр хүүхдэд бялуу болгоноос нэг нэг хэрчээд цонхон дээр тавьж,

–Идэцгээ! гэв.

Василий Петрович архи аягаллаа.

–За баярын төлөө!

–Ширээн доор уулзацгаая! гээд Катя Сашагаас бусдыг тойруулан харав. Тэрээр Сашаг анх удаа танилындаа дагуулан ирсэн нь энэ, тэгээд ч анх удаа цагаан архи ууж байгаа нь энэ. Саша тэр хоёр урьд нь зөвхөн улаан дарс л ууж үзсэн ажээ.

Маруся Саша руу дохиж,

–Яасан сайхан хар нүдтэй залуу уургалаа вэ! гэж хөгжилтэй өгүүлэхэд Катя,

–Хар нүдтэй бас буржгар үстэй гээч хэмээн жуумалзав.

–Үс ч өсөх насанд буржийдаг, өтлөх насанд хугардаг эд дээ гээд Василий Петрович дахин шилтэй юмаа барьж авлаа. Сашад түүний царай бүрзгэр санагдахаа больсны гадна дуу шуутай байх гээд байгаа нь танилцаж ханьсах гэсний шинж. Маруся ч гэсэн учир мэдэх хүний найрсаг харцаар бүгдийг мялаан сууна.

Марусягийн ивээл, буйдхан энэ байшин, хажуугийн айлаас сонсдох дууны ая, гармонь хөгжмийн эгшиг цөм л Сашагийн сэтгэлд аятайхан санагдана.

–Та яагаад юм идэхгүй байна? гэж Маруся асуулаа.

–Баярлалаа, идэж байна, сайхан бялуу байна.

–Хийх юм нь байдагсан бол энэ байтугайг жигнэхгүй яахав. Хөрөнгө гэхэд л ер олдохгүй юм. Ашгүй, Василий Петрович авчирч өгөөд энэ.

Василий Петрович гурил исгэх хөрөнгөний тухайд нэг чухал юм хэлэв.

Хүүхдүүд бялуу нэмж гуйлаа.

Маруся тэдэнд дахин нэг нэг хэрчиж өгөөд,

–Зөвхөн та нарт хийсэн гэж бодоо юу?! Одоо болсон шүү, гар нүүрээ угаацгаа! гэв.

Тэгээд тэдний хөнжил дэвсгэрийг эмхэлж аваад хөршийнх рүүгээ гарлаа.

Хүүхдүүд унтахаар явцгаав. Дараа нь Василий Петрович ч явахаар зэхэв. Маруся түүнийг гаргаж өгөхөөр явахдаа,

–Цэвэр цагаан даавуу шүүгээнээс аваарай гэж Катяд хэлэв.

Марусяг гармагц Саша,

–Энэ хүн Марусяд ямар хэрэгтэй юм бэ? гэж асуув.

–Хар хүн нь хүүхдийн тэтгэврээс зугтаад олдохгүй байхад одоо яах вэ, аж төрөх хэрэгтэй биз дээ.

–Хүүхдүүдийн нүүрэн дээр үү?

–Өлөн байцгаасан нь дээр гэж үү?

–Хөгшин эр байна шүү дээ.

–Маруся ч залуу биш шүү дээ.

–Тэгвэл яагаад нийлдэггүй юм бэ?

Катя хөмсөг зангидан,

–Тэгвэл чи яагаад надтай суухгүй байгаа юм бэ? гэж асуув.

–Чи хүнтэй суумаар байна уу?

–Суумаар байна...За, тэр ч яахав! Аль вэ, унтацгаая.

Катягийн ингэж хэлсэн нь тун хачин байв. Урьд нь бол тэр хоёр анх удаа уулзаж байгаа юм шиг л оролдож байж эзэмдүүлдэг байсан атал өнөөдөр өөрөө ороо засаж, өөрөө хувцсаа тайлах аж. Гагцхүү,

–Гэрэл унтраа гэснээс өөр юм хэлсэнгүй.

Дараа нь халмигийг нь хуруугаараа оролдов...

–Чи чадалтай эр юм, охид чамд дурладаг байлгүй, гэхдээ чи болгоомжгүй хүн гээд Катя дээрээс нь өнгөйж Сашагийн нүд рүү цохлон харснаа, – Нэг хар нүдтэй хөөрхөн амьтныг

чамд гаргаж өгнө, чи айхгүй байна уу? гэж асуулаа.

Ийм юм эрт орой хэзээ боловч тохиолдох нь зайлшгүй байсан билээ. Гэвч яахав дээ, үрээ хөндүүлчихнэ биз, хэн хэнд нь хүүхэд хэрэггүй юм чинь.

–Чи жирэмслээ юү?

Бүсгүй амьдралынхаа зовлон зүдгүүрээс өмгөөл ивээл хайх мэт Сашагийн мөр лүү нь толгойгоо шигтгэн наав.

Саша энэ бүсгүйн тухай юу мэдэх билээ? Хаана суудаг вэ? Эгчийндээ юү? Нийтийн байранд уу? Хөлсний оромжинд уу? Үр хөндөхий! Гэрийнхэндээ юу гэж хэлэх вэ? Ажлынхаа газар ямар акт үзүүлэх вэ? Гэтэл үр хөндөх хугацаа нь хэтэрчихсэн байвал яана? Хүүхэдтэй хүн хаачих ч билээ дээ?

–Хэрвээ жирэмсэн бол төрүүл, хоёулаа гэрлэе.

Бүсгүй толгойгоо өндийлгөлгүй,

–Хэн гэж нэр өгөх вэ? гэж асуулаа.

–Шийднэ дээ, цаг их байна.

Хүүхэн дахин инээд алдаад түүнээс хөндийрсхийв.

–Чи гэрлэхгүй шүү дээ, би ч гэсэн чамтай суухгүй. Чи хэдтэй билээ? Хорин хоёр уу? Би хүртэл чамаас эгч байна. Чи боловсролтой хүн, гэтэл би? Дөнгөж зургадугаар анги төгссөн... Хүнтэй сууна, гэхдээ чамтай биш.

–Хэнтэй? Сонин байна.

–Сонин гэнээ...Нэг залуу, манай тосгоных.

–Тэр чинь хаа байгаа юм бэ?

–Хаа, хаа... Уралд байгаа, ирээд намайг аваад явна.

–Юу хийдэг юм бэ?

–Юу юу...Механикч.

–Чи түүнийг аль хэзээний мэдэх юм уу?

–Нэг тосгоных гэж хэллээ шүү дээ.

–Яагаад тэр чинь өдий хүртэл чамтай суугаагүй юм бэ?

–Солио нь дарагдаагүй байсан юм, тэгээд л суугаагүй байхгүй юу.

–Одоо тэгээд дарагдаа юу?

–Одоо хэдийн гуч хүрчихсэн. Тэр ямаршуухан хонгоруудтай байсан гэж санана...

–Чи түүнд сэтгэлтэй юу?

–За тийм, сэтгэлтэй...

–Тэгээд яах гэж надтай уулздаг юм?

–Яах гэж, яах гэж гэнэ шүү...Надад ч гэсэн амьдрах хүсэл байна. Сэргийлэхийнхэн шиг л байцаагаад байж гэнэ, янзын эд шүү!

–Тэр чинь тэгээд хэзээ ирэх юм бэ?

–Маргааш.

–Тэгэхлээр чи бид хоёр дахиад уулзахгүй юм уу?

–Хуримандаа чамайг урих уу?...Тэр булиа эр, ганцхан дэлсэхэд л чи байхгүй болно.

–Гайгүй байлгүй.

–Ээх, ээх...

–Чи чинь жирэмсэн шүү дээ.

-- Хэн тэгж байна?

-- Чи өөрөө хэлсэн шүү дээ.

–Би юу ч хэлээгүй. Чи өөрөө зохиож байна.

Хаалга зөөлхөн тогшив. Катя Марусяд хаалга тайлж өгөөд буцаж хэвглээ.

–Гаргаад өгчихлөө. Та нар цай ууцгаах уу? гээд Маруся гэрлээ асаав.

Саша өмд рүүгээ гар явуулав.

–Та яачихав? Битгий санаа зов гэж Маруся өгүүлсэнд Катя жуумалзан,

–Ичимхий эр шүү, надтай зугаацахаасаа ичээд гэрлэх санаатай байгаа юм гэхэд Маруся,

–Гэрлэх амархан, бас салах ч амархан хэмээв.

Саша үлдсэн архийг нэг аяганд хийгээд бялуунаас хазлаа. Ерөнхийдөө бүх юм ийнхүү золтой төгсөж байгаад мань хүн Катяд талархах ёстой. Тэр механикч гэдэг нь үнэхээр байгаа л байх,

гэхдээ хэргийн учир тэр хүнд биш. Харин Катя өөрийг нь дахиад л даапаалж байхад мань эр шалдаа буугаад өгчихдөг л тэнэг толгой юм даа. Саша бослоо.

–Чи хаачих нь вэ? гэж Катя асуув.

–Харья.

Маруся сандран,

–Та яаж байна, юу гэсэн үг вэ? Унтаад өглөө явцгаана биз, би айлдаа хоночихно, та нар хэнд ч саад болсон юм алга гэж үглэв.

–Явах хэрэгтэй байна.

Катя муухай харлаа.

–Замаа олох уу даа?

-- Төөрөхгүй ээ.

Катя Сашаг өөр лүүгээ чангаагаад,

–Үлд л дээ гэв.

–Явна аа. Аз жаргалтай яваарай.

Бас ч гэж сайн бүсгүй шүү! Тоогүй л хэрэг болох нь. Ингээд Катя л утасдахгүй бол энэ хоёр дахиад хэзээ ч уулзахгүй гэсэн үг. “Эгч аашилна” гээд хаягаа өгдөггүй байсан болохоор хаягийг нь мэдэхгүй, тэр ч байтугай “Үйлдвэрийн үүдэнд зүүгдчихнэ” гээд ямар үйлдвэрт ажилладгаа ч хэлээгүй.

Бүсгүй үүнээс өмнө автомат телефоноос хааяа утасдаад тэр хоёр кино үзэх буюу цэнгэлдэх хүрээлэн рүү явдаг, дараа нь Цэнгэл цэцэрлэгийн гүн рүү ордог байсан билээ. Сарны гэрэлд зотон даавуун сандал цайрна. Катя харцаа буруулна. “Яах чинь энэ вэ... Болиоч, болиоч гэнэ...” Тэгснээ налаад наалдаад ирнэ. Уруул нь омголтоод хув хуурай. Холцруутсан гараараа үсийг нь оролдоно.

–Би чамайг анх хараад цыган гэж санасан шүү. Манай тосгоны ойролцоо цыганууд буудаллаж байсан юм, яг чам шиг хар. Харин чиний арьс гөлчгөр юм.

Зун Сашагийн ээжийг зусланд эгчийндээ байх үеэр Катя тэдний гэрт ирдэгсэн. Орцны үүдэн дээр суугаа авгай нараас ичсэндээ нүд нь ууртай гялалзан “Эмс цоо ширтэж байна. Энэ насандаа дахиад яасан ч ирэхгүй”.

Тэрээр утасдахдаа голдуу чимээгүй байж байгаад утсаа тасалчихаад дахиад залгана...

–Катя чи юү?

–Тийм, би л байна...

–Сая яагаад дуугарахгүй байсан бэ?

–Би ерөөсөө утасдаагүй юм чинь...

–Уулзах уу?

–Бид чинь хаа уулзах болж байна?...

–Цэнгэлдэх хүрээлэнд үү?

–Бодож олов оо бас... Охидын талбай руу хүрээд ир.

–Зургаад уу, долоод уу?

–Бас, зургаад гээд би гүйх гэнэ...

Саша энэ бүхнийг одоо дурсан санаж түүний утасдахыг хүлээв. Нөгөө явдлын маргааш бүсгүй гэнэтхэн утасдаж магадгүй хэмээн Саша сургуулиасаа бушуухан харихсан гэж бодсон ажээ. Гэвч Октябрийн баярт зориулсан ханын сонин хийхээр үлдээд, дараа нь намын үүрийн товчооны хуралд дуудагдав.

Үүдний орчмоор сул суудал байсангүй. Саша шахуу суусан хүмүүсийг шүргэн эгнээ сандлуудын дундуур чихэлдэхдээ намын үүрийн товчооны нарийн бичгийн дарга Баулины эгдүүг хүргэснээ харцаар нь мэджээ. Хээгүй болж ирээд гөжүүд дугариг царайтай, халиун үстэй, оготор хүзүүгээ ороосон захных нь хоёр цагаан товчыг товчилсон хөх сатин цамцны цаанаас түхэлзэн буй ханхар цээжтэй Баулин Сашаг буланд очиж суутал дагуулан харснаа дахин Криворучко руу хандан,

–Та л оюутны байр барих ажлыг тасалж шүү дээ. Бодит шалтгаан хэнд ч сонин биш! Нөөц хөрөнгийг гавшгай барилга байгууламж руу шилжүүлсэн гэнэ үү? Та Магниткаг хариуцаагүй, сургуулийг хариуцаж байгаа шүү! Яагаад хугацаа бодитой биш гэдгийг хэлээгүй юм бэ? Яагаад биелүүлээгүй вэ? Та намд хорин жил болж байгаа биз дээ?... Өмнөх гавьяа зүтгэлийн чинь тухайд бол хөлд чинь мөргөнө, харин гаргасан алдааны хувьд бол хатуу ярих болно доо гэв.

Баулины ярьж байгаа аясыг хараад Саша гайхлаа. Орлогч захирал Криворучкоогоос оюутнууд хулчганадаг билээ. Түүний цэрэгт байсан алдартай намтар түүхийн тухай сургуулиар бишгүй ярилцана. Тэрээр одоо хүртэл цэрэг өмд цамц, савхин гуталтай явдаг. Доод хоёр зовхи нь шолхойсон, урамгүй унжуу хамартай энэ бөгтөр хүн хэзээ ч хэнтэй ч юм ярьдаггүй, тэр ч байтугай мэндлэхэд хүртэл толгой мэхэсхийн хариулна.

Криворучко сандлын аравч тулан зогсох агаад хуруу нь чичирч байгааг Саша үзэв. Байнга ширүүн дориун байдаг хүн ийнхүү шалдаа буусан байх нь өрөвдөлтэй харагдах ажээ. Барилгын материал үнэхээр өгөхгүй байсан шүү дээ. Гэтэл одоо энэ тухай хэн ч бодохыг хүсэхгүй байна. Гагцхүү Сашагийн факультетийн декан уужуу дотортой латви эр Янсон л

сургуулийн захирал Глинская руу хандан,

–Хугацааг нь нэмж өгвөл яасан юм бэ? гэж эвлэрэнгүй өгүүлэв.

–Ямар хугацаа?! хэмээн Баулин эгдүүтэй, хээгүй байдлаар асуулаа.

Глинская дуугарсангүй. Тэрээр ийм үл бүтэх орлогч тулгаж өглөө гэсэн шиг гомдсон царайтай сууна. Өндөр чацтай, тахилзаж гулжганасан аспирант Лозгачёв босож гараа жүжиглэх мэт занган,

–Үнэхээр, хүрзээ хүртэл Магнитка руу явуулчихсан гэж үү? Оюутнууд хөлдүү газрыг хуруугаараа ухацгаагаа юу? Энд группийн комсомолын зохион байгуулагч сууж байна, тэд нар хүрзгүй яаж ажилласныг яриад өг л дөө гэв.

Баулин Саша руу сониучирхан харлаа. Саша босов.

–Бид хүрзгүй ажиллаагүй. Нэг удаа агуулах хаалттай байсан. Дараа нь нярав эргэж ирээд бидэнд хүрз тавьж өгсөн.

–Та нар удаан хүлээсэн үү? гэж Криворучко толгойгоо гудайсан чигээрээ асуув.

–Арваад минут.

Лозгачёв Сашагаар гэрчлүүлэх гэсэн нь бүтэлгүй болсонд өөрөө будилсан бус Саша будилсан юм шиг хачирхан толгой сэгсрэв.

–Тэгээд ая зүйгээ олсон хэрэг үү? гэж Баулин хямсайхад,

–Олсон гэж Саша өчив.

–Тэгвэл та нар хичнээн цаг ажиллаж, хичнээн цаг сул зогссон бэ?

–Материал байгаагүй шүү дээ.

–Чи хаанаас мэдэж байгаа юм бэ?

–Бүгдээрээ л мэдэж байгаа шүү дээ.

–Панкратов, чи дэмий өмгөөлж байна, зохисгүй явдал! хэмээн Баулин ширүүлэв.

Товчооны гишүүд Криворучко руу харахгүйг хичээн түүнийг намаас хөөхөөр санал өгцгөөлөө. Ганцхан Янсон түдгэлзэв.

Криворучко бөгтөр дээрээ бөгтийсөөр өрөөнөөс гарав.

–Доцент Азизян өргөдөл ирүүлжээ гээд Баулин “Панкратов, чи одоо юу хэлэхсэн бол!” гэж асуух мэт Саша руу харлаа.

Азизян Сашагийн группт социалист тоо бүртгэлийн үндэс заадаг юм. Гэтэл тоо бүртгэл битгий хэл үндэс суурийг нь ч ярихгүй, харин тэр үндсийг нь гуйвуулж байгаа хүмүүсийн тухай ярина. Саша нягтлан бодох гэж чухам юу болох тухай бидэнд наад захын ойлголт өгвөл зүгээрсэн гэж шууд хэлжээ. Овжин зальтай, муу аргатай буржгар Азизян тэгэхэд инээгээд өнгөрсөн аж. Гэтэл мань хүн одоо Сашаг тоо бүртгэлийн тухай шинжлэх ухааны марксист үндэслэлийг эсэргүүцсэн гэж буруутгажээ.

–Ийм явдал болсон уу? гээд Баулин Саша руу хүйтэн цэнхэр нүдээр ширтэв.

–Би онол хэрэггүй гэж хэлээгүй. Нягтлан бодох ухаанаар бид мэдлэг олж аваагүй гэдгийг л хэлсэн.

–Шинжлэх ухааны намч чанар чамд хамаагүй юу?

–Хамаатай. Тодорхой мэдлэг ч бас хамаатай.

–Намч чанар, тодорхой чанар хоёрт ялгаа байна уу?

Лозгачёв дахиад бослоо.

–За нөхдүүд ээ... Шинжлэх ухааныг улс төргүй гэж ил номлож байхад... түүнээс гадна Панкратов Криворучкогийн тухай онцгой бодлоо намын үүрийн товчоонд тулгахыг оролдсон, оюутан олон түмний төлөөлөгч болох гэсэн. Ер нь ингэж ярихад, Панкратов, та энд хэнийг төлөөлж байна вэ?

Янсон баргар царайлан, пүндгэр цүнхээ бүдүүн хуруугаараа тогшин сууна.

Глинская Баулин руу эргэж харав.

–Комсомолын байгууллагад шилжүүлэх юм уу...

Захирлын дуунд өчүүхэн оюутны яльгүй асуудал хэмээн даргархан залхуурсан аяс мэдэгдэв. Глинскаягийн саналд Баулин сэтгэл дульхан байх ёстой гэж Лозгачёв санаад түүн рүү хяламхийж,

–Намын байгууллагын товчоо зайлсхийх ёсгүй... гэв.

Энэ болчимгүй үг бүхнийг шийдэх нь тэр.

–Зайлсхийсэн хүн ерөөсөө алга, гэхдээ тогтсон журам байна. Комсомол хэлэлцэг. Комсомолын улс төрийн өсөлт ямар байгааг харъя гэж Баулин хөмсөг зангидав.

Өлгүүрт хүрэн савхин дээл өлгөөтэй байв... Марк ах иржээ!

–Зугаалсхийгээд л байна уу?...

Саша Марк ахынхаа сахлаа мөлчийтөл хуссан хацар дээр үнсэв. Түүнээс гаансны сайхан

тамхи, даруухан үнэртэй ус ханхалж байх нь ээжийнх нь хэлдэг нөгөө “аминдаа арчаатай ганц бие эрийн тохилог намба” даруй мөн. Марк гучин тавтай гэхэд илүү оворжуу харагддаг, халзарч яваа бүдүүн хөгжүүн эр. Харин гагцхүү шар туяатай шилний цаанах цоргим хурц нүд л аж үйлдвэрийн өмнөө барьдаг дарга нарын нэг энэ хүний чин зоригийг илтгэнэ. Тэрээр Дорнод нутагт бариулж байгаа аварга том барилга байгууламж шигээ бараг домогт хүн. Энэ барилга нь дайсны нисэх хүчний савар хүрэхгүй. Зөвлөлт Холбоот Улсын төмөрлөгийн шинэ бааз, пролетарийн гүрний стратегийн ар тал юм.

–Чамтай уулзаж чадахгүй нь гэж саналаа, тэндээ хонох юм байх л гэж...

–Саша дандаа гэртээ хонодог юм гэж ээж нь өгүүлэв.

Ширээн дээр улаан дарс, бүдүүн хиам, шпрот загас, “түрэг талханцар” гээд Маркийн ирэх болгондоо авчирдаг амтаг идээнүүд байв. Ээжийнх нь “шидэт” зуухандаа жигнэдэг уламжлалт бялуу ч байхыг үзвэл Марк ирнэ гэдгээ урьдчилан хэлж амжсан бололтой.

–Хэр удах вэ? гэж Саша асуув.

–Өнөө ирсэн, маргааш явна.

–Сталин дуудсан гэнэ гэж ээж нь хэлэв.

Энэ авгайн ганц бахархал нь дүү, хүү хоёр нь юм. Мушгирсан буурал үстэй, одоо хэр хөөрхөн цагаан царайтай, нуруу намхан, таргандуу энэ авгай нөхөртөө хаягдсан учир өөр хэнээрээ ч бахархах билээ дээ.

Марк буйдан дээр байсан боодолтой юм руу гараараа зааж,

–Задал даа гэв.

Софья Александровна уяаг нь тайлах гэж оролдлоо.

–Аль вэ нааш нь!

Саша боосон олсыг хутгаар огтолчихов. Марк эгчдээ пальтоны даавуу, ноолууран алчуур, Сашад хар хөх бостон даавуун костюм авчирчээ. Яльгүй үрчийсэн пиджак дурайтал таарлаа.

–Яг хэв хэмжээ авсан юм шиг л байна. Их баярлалаа, Марк минь. Энэ чинь бүр нөмрөх юмгүй болчихсон юм гэж ээж нь олзуурхан магтав.

Саша сэтгэл хангалуун тольдоно. Марк дандаа яг хэрэгтэй юм бэлэглэдэг хүн. Түүнийг жаахан байхад нь гуталчинд дагуулж очиж сайхан урт түрийтэй хромон гутал хийлгэж өгсөн юм. Тийм гутал айл саахалтын ч, анги сургуулийнхны хэнд ч байгаагүй, тэр үед мань хүн гутлаараа их л бахархаж явсан сан. Одоо хүртэл үнэр нь санаанаас эс гарна. Бас гуталчны пингээс ханхалж байсан савхи, тосны хурц үнэр санаанд тодхон буй.

Энэ орой Марктай хэд хэдэн удаа утсаар ярив. Тэрээр материалын нөөц, хэмжээ, тээврийн

цуваа гэхчлэнгийн асуудлаар бүдүүн захирангуй дуугаар тушаал буулгаж, Арбатад айлд хонож байгаагаа мэдэгдэн, өглөөний наймд машин ирүүлэхийг даалгалаа. Өрөө рүү буцаж орж ирээд лонх руу жишүүхэн харав.

–Өө хөө!

–Зохиж л байвал ууж л бай, нөхөр минь, зовлон юугаа даруулж бай, нөхөр минь хэмээн Саша Маркийн дуртай дууг аялав. Бүр жаахан байхдаа өөрөөс нь анх удаа энэ дууг сонссон ажээ.

–Чимээгээ аяд, чимээгээ аяд, элдэв бодлыг энэхэн шөнөдөө умартъя хэмээн Марк дууг өргөн аваад – Тэгдэг билүү? гэхэд Саша,

–Яг тийм! гээд дахин дууллаа.

Маргааш яг энэ үед

Чека[2] хүрээд ирж магадгүй

Магадгүй яг тэр цагт

Колчакийг сөнөөж болзошгүй...

Саша хоолой, сонсгол хоёрыг ээжээсээ удамлан авчээ. Ээжийг нь радиогоор дуулуулах гэж урьж байсан удаатай, харин аав нь явуулаагүй билээ.

Маргааш яг энэ үед

Нөхөд маань ирж магадгүй

Мадаггүй яг тэр цагт

Биднийг хөнөөж болзошгүй.

–Сайхан дуу шүү гэж Марк хэллээ.

–Даан ч та хоёр хараагүйчүүдийн найрал шиг муу дуулж байна гэж Софья Александровна өгүүлэв.

–Хоёр сохрын хослол хэмээн Марк инээд алдлаа.

Маркийг буйдан дээр унтуулахаар зэхэв. Саша зуслангийн зотон даавуун бүрээстэй орон дээр хэвглээ.

Марк пиджак, мөрөвч, цамцаа тайлаад зах ханцуйгаараа цэнхэр туузаар эмжсэн дотуур цамцтайгаа угаалгын өрөө рүү оров.

Саша түүнийг хүлээх зуур толгойгоо салаавчлан хэвглээ...

Хурлын дараа шатаар бууж явахдаа Янсон түүний мөр рүү нөхөрсгөөр алгасан. Энэ цорын ганц урам сэргээх хүнлэг дохио түүний сэтгэлийн хоосролыг улам тодосгосон. Бусад зарим нь рүүгээ, зарим нь гуанз руу яарч байгаа дүр үзүүлцгээсэн. Трамвайны зогсоол руу балиар гудамжаар явж байхад нь хар өнгийн хөнгөн тэрэг хажуугаар нь давхиж өнгөрөхөд урд талын суудалд суусан Глинская арагшаа эргэн ардах хүмүүстэйгээ юм ярьж явсан.

Тэдний ярьж байсан байдал, өөрийнх нь тухай ч бодохгүй, дэргэдүүр нь анзаарах ч үгүй давхин өнгөрч байгаа энэ тэрийг бодохоос шударга бусаар шоовдорлуулснаа мэдрэх, бас толгойд хов хоосон оргих сэрэл дахин эзэмдсэн.

Саша захирал Глинскаяг урьд нь сургуулийн эцэг эхийн хорооны хурал дээр харсан, дунд сургуульд байхын мэдэх билээ. Түүний хүү гэж уулын спортоос өөр юм сонирхдоггүй, яриа хөөрөөгүй унжуу царайтай Янтай Саша нэг ангид сурдаг байсан юм. Энэ хүүхэн Коминтерний нэг ажилтны авгай бөгөөд польш аялга нь түүний тас тус яриаг хиймэл аястай хүйтэн болгодогсон. Гэлээ ч гэсэн Глинская товчооны хурал дээр арай дуугүй өнгөрөмгүй санагдсан. Оюутны байрыг Криворучкогоос дутуугүй хариуцах ёстой. Гэтэл тэрээр дуугараагүй.

Марк гар нүүрээ угааж сэргэчихээд буцаж ирмэгц аяныхаа цүнхнээс үнэртэй ус гаргаж түрхээд буйдан дээр хэвтэн, эвтэйхэн хэвтэх гэж хэд хөрвөөснөө шилээ авч, тавих газар хайн нүдээ анивчив.

Тэр хоёр хэсэг зуур чимээгүй хэвтсэнээ Саша,

–Сталин яах гэж дуудаав? гэж асуув.

–Намайг Сталин дуудсан биш, түүний зааврыг уламжлах гэж дуудсан юм.

–Түүнийг чац багатай гэж ярьцгаах юм.

–Чи бид хоёр л гэсэн үг.

–Харин индэр дээр байхдаа өндөр юм шиг санагддаг шүү.

–Тийм шүү.

–Тавин насных нь ойгоор баяр хүргэсний хариуд “нам намайг өөрийнхөө дүр төрхөөр бүтээсэн” гэх маягийн юм хэлсэн байсан нь миний сэтгэлд нийцээгүй гэж Саша өгүүлэв.

–Баярын ерөөл өөрт нь биечлэн хамаагүй, намд хамаарна гэсэн утга.

–Сталин хэрцгий, ёс бус авирладаг гэж Ленин бичиж байсан гэдэг үнэн үү?

–Чи яаж мэдээв?

–Тэр ямар хамаа байна... Мэдэж л байна. Бичиж байсан, тийм биз дээ?!

–Энэ бол зөвхөн хувийн шинж чанар, энэ гол зүйл биш. Гол нь улс төрийн шугам гэж Марк хэлэв.

–Энэ хоёрыг чинь салгаж болдог юм уу? хэмээн Саша зөрөх зуур Баулин, Лозгачёв хоёр санаанд нь оров.

–Чи эргэлзэж байна уу!

–Яг бодсон юм алга. Би ч бас Сталины төлөө л байгаа шүү дээ. Гэхдээ магтаалын үг арай цөөн байвал зүгээрсэн гэж бодох юм, одоо ч чих баалмаар байна шүү.

–Ойлгомжгүй л бол буруу гэж хараахан болохгүй. Намдаа итгэ, намын мэргэн ухаанд итгэ. Чангахан цаг ирж байна гэж Марк хариулав.

Саша тамшаалснаа,

–Өнөөдөр биеэрээ амслаа гээд товчооны хурлын тухай ярилаа.

–Нягтлан бодох ий! Энэ нөгөө яах зарчмын асуудал мөн үү...

–За боль доо! Зарчмын асуудлыг бүх насаараа хүлээж болно...

–Хичээл дээр зөрөх чинь зохисгүй зүйл

–Намайг зохисгүй зүйл хийсэн гээгүй, улс төрөөс хөндий байна гэж буруутгаж байгаа юм. Тэгээд үүнийгээ хүлээ гэж шаардсан, ойлгож байна уу?

–Алдаа хийсэн бол хүлээж болно шүү дээ.

–Миний хүлээхийг тэд хэзээ ч үзэхгүй дээ. Ямар юмныхаа бурууг хүлээх юм бэ? Гүжирдлэг!

–Танай захирал чинь Глинская хэвээрээ юу?

–Хэвээрээ.

–Товчооны хурал дээр байсан уу?

–Байсан.

Марк Александрович машинаа түрүүлж явуулчихаад өөрөө явган явав.

Намрын тунгалаг өглөө бие сэргэм сэрүү татна. Албан хаагчид ажил руугаа яарцгааж, талхны дэлгүүрийн гадаа хүүхнүүд шуугилдан, тамхины мухлагийн дэргэд эрчүүд чимээгүйхэн эгнэн зогсжээ.

Марк Александрович эгч нарынхаа дотроос Соняг хэзээний онцгойлж үздэг, тэгээд ч одоо нөхөртөө хаягдаж бүр ч хөөрхий байгаа учир улам элгэмсэн өрөвдөн хайрлах ажээ. Бас Сашад ч хайртай. Яалаа гэж хүүхдийг гоочлоод байгаа юм бол? Үнэнийг л шударгаар хэлсэн байна шүү дээ, гэтэл сэтгэлийг нь тарчлааж, хийгээгүй гэм хүлээ гэж тулгасан байна. Би ч гэж бас гэмээ хүлээ л гэлээ...

Марк Александрович Арбатын талбайг хөндлөн гарч саяын хөл хөдөлгөөнтэй Арбаттай жишихэд санаанд оромгүй эл хуль, нам гүм санагдах Воздвиженка дагуу алхав. Гагцхүү Цэргийн худалдааны дэлгүүр онгойхыг хүлээсэн бөөн улс, түүнээс арай цөөн хэсэг хүн Калинины хүлээн авах газрын тэрүүхэнд шахцалдан байхаас өөр хэн ч алга. Марк Александрович хүлээж байсан машиндаа сууж, Моховая, Охотный ряд гудамж хоёроор өгсөн Театрын, Лубянын талбайгаар дайран Ногины талбай руу явав. Тэнд хуучин Хэргийн хороо байсан урт хонгилтой, тоо томшгүй олон өрөөтэй таван давхар нүсэр том саарал байшинд Хүнд аж үйлдвэрийн ардын комиссарын газар байрлана.

Эх орны өнцөг булан бүрээс энэ байшинд мянга мянган хүн ирнэ. Энд бүх юмыг шийддэг, төлөвлөдөг, баталдаг ажээ. Марк Александрович Ардын комиссарын газраар эргэх тойрох ажлаа газрын дарга нараас эхэлсэнгүй, урьдын адил хэлтэс, тасгуудаас эхэллээ. Дэлхийд гаргуутай том барилга байгууламжийн дарга, Оржоникизегийн дотнын хүн Рязанов ийнхүү юуны өмнө жирийн ажилтнууд руу ирж байгаа нь тэдэнд үнэхээр аятайхан байлаа. Ингэхлээр тэднийг тоож байгаа хэрэг. Тэгээд ч тэд нар түүний ажил явдлыг уриалгахан хөөцөлдөж, төлөвлөгөөт таван жилийн сүр, бахархал хоёр болж байгаа заводын эрх ашгийн үүднээс, өөрөөр хэлбэл Марк Александровичийн хүссэнчлэн хамаг ажлыг нь шийдэж болгож өгнө.

Тэрээр хэлтсүүдээр оронгоо хоёр давхарт гарч хэд хэдэн хонгилоор сүлжин явснаа дахин шатаар өгсөж, өөр нэг шатаар уруудаад энэ байшингийн хөл чимээ багатай, ардын комиссар, түүний орлогчдын албан тасалгаа байдаг жигүүрт ороод ирэв. Хивс өвч дэвссэн хүлээлгийн өрөөнд байгаа харилцуур утаснууд тавьсан олон ширээний цаана нарийн бичгийн дарга хүүхнүүд сууцгаана. Тэд нар Рязановыг таних тул тэрээр урьдчилан хэлүүлэлгүй Будягины өрөө рүү орлоо.

Намын Төв Хорооны гишүүн, хамт цөллөгт байж Сталинтай танил болсон Будягиныг хэдэн сарын өмнө хилийн чанадаас эргүүлэн дуудаж ирүүлсэн юм. Европын томоохон гүрэнд сууж байсан элчин сайдыг ардын комиссарын орлогчоор ийнхүү томилжээ. Түүнийг дипломат ажлаас татаж авсан нь санаандгүй хэрэг биш, түүний талаар сэтгэл дундуур байсан гэдэг. Будягиний хар сахалтай хатингар царай, өтгөн хөмсөгтэй бор нүднээс ямар нэгэн зүйлийг олж мэдэх арга байхгүй. Цэргийн комиссарын шинелийг элчин сайдын өмсгөлөөр, мужийн

Онцгой комиссын даргын савхин хүрмийг трестийн захирлын костюмаар сольсон энэ ажилчин сэхээтнүүд Марк Александровичийн хувьд Хувьсгалын сүрт үзэл санаа, Диктатурын бүхнийг бут ниргэх хүчний бодит биеллийг илтгэдэг билээ.

Дөрөвдүгээр зуухны тухай ярьж байгаа ажээ. Энэ зуухыг төлөвлөгөөний ёсоор найман сарын дараа асаах бус таван сарын дараа буюу Намын Арван долдугаар их хурлын өмнө асаах ёстой болжээ. Аж ахуйн ашиг сонирхол улс төрийн зайлшгүй шаардлагаас болж хохирч байгааг Марк Александрович, Будягин хоёрын хэн хэн нь ойлгож байгаа билээ. Гэвч Сталины таалал тийм байжээ.

Бүх юмаа ярилцсаны дараа Марк Александрович,

–Танай охинтой нэг сургуульд сурдаг миний зээ Саша Панкратовыг та таних уу? гэж асуув.

–Танина гээд Будягины царай дахиад төв болов.

–Шал дэмий явдал...

Марк Александрович Будягинд хэргийн учрыг ярьж өгөв.

–Саша шударга залуу гэж Будягин өгүүлэв.

–Нягтлан бодох ухааныг улс төргүй болгосон гээд байгаа, та бодоод үзээч! Тэдний захирал нь Глинская, би түүнийг танихгүй, та танина. Танд яршигтай биш бол нэг ярихгүй юу. Залуу хайран байна, тонилгочихно шүү. Би Чернякт хэлж болохсон, гэхдээ районы намын хороо хүргэмээргүй байна.

–Черняк нарийн бичгийн даргаа хэдийн больсон

–Яагаад?

–Тэгээд...

–Бид чинь юунд хүрэх болж байна?

Будягин дал мөрөө хавчив.

–Их хурал нэгдүгээр сард...гээд ямар нэг завсаргүй – Сашка тун сайн хүү, манайхаар ирдэг юм. Хачин юм даа, надад юу ч яриагүй шүү.

–Тэр чинь хүнээс тусламж гуйдаг хүн биш дээ.

–Глинская ямар нэгэн юм хийж чадах болов уу? хэмээн Будягин эргэлзэв.

–Мэдэхгүй юм. Би ямар ч байсан түүнийг хэмлүүлэхгүй. Залуусыг эрэмдэглүүлж болохгүй, тэд амьдралаа дөнгөж эхэлж байна.

–Одоо ч ийм явдал ганц чиний зээд тохиолдож байгаа ч биш шүү гэж Будягин хэлэв.

Марк Александрович доошоо үсчин рүү бууж үсээ засуулаад, сахлаа яагаад ч юм хусуулав. Тэгтэл үсчин үнэртэй ус шүршчихлээ. Хурц үнэр нь сэтгэлд таараагүй тул сахлаа хусуулсандаа харамсав. Ийнхүү хөндлөнгийн нялуун үнэртэн ханхлуулсаар коллегийн гишүүдийн гуанз руу орлоо.

Буфетны худалдагч хүүхэн түүн рүү эргэж харав.

–Нөхөр Рязанов гуай, таныг нөхөр Сёмушкинтай уулзаарай гэсэн шүү.

Тэрээр дээшээ гарав. Оржоникизегийн нарийн бичгийн дарга Анатолий Сёмушкин Марк Александрович яг хэрэг болсон үед ойр байгаагүйд дурамжхан буйгаа илэрхийлэн хайнгахан мэндлэв. Сёмушкин хэнийг ч байсан “чи” гэдэг, Сергогоос[3] өөр хэнийг ч тоодоггүй учир түүнээс Сергогоос дутуугүй айцгаадаг билээ. Иргэний дайны үед түүний туслах байж байгаад хорин нэгэн оноос буюу Өвөр Кавказад байхад нь ч, Төв шалган байцаах комисс ба Ажилчин тариачны байцаан зааварлах газар байхад нь ч, одоо энэ Хүнд аж үйлдвэрийн ардын комиссарын газар ч туж нарийн бичгийн дарга нь яваа.

Сёмушкин дуурайхын аргагүй албархаг болж ирээд хямсгар дурамжхан царай гарган утасны ноймер эргүүлэв...

–Нөхөр Рязанов утсан дээр ирээд байна...

Тэгээд харилцуурыг Марк Александровичид өгөв.

...Түүнийг дөрвөн цагт Кремльд хүлээж байх болжээ...

Чухам үүний учир дуудсан гэдгийг Марк Александрович гадарлаж байжээ. Гэвч буцах билетийг нь хэдийн өгсөн учир уулзахаа больсон хэрэг гэж дотроо шийджээ. Гэтэл одоо дөчин минутын дараа мань хүн Сталины дэргэд байж байх нь.

Сёмушкин өөр нэг аппаратаар Бобринскийн химийн комбинаттай холбоо барьгал цаадуул нь Григорий Константинович талбай руу яваад өгсөн гэж хариулав. Гэвч Сёмушкин Рязановыг Оржоникизегийн зааврыг авалгүй Сталинтай уулзсанаас хоцорч очсон нь дээр гэж үзэж байгаа бололтой түүнийг дэргэдээ барьж ийш тийш нь утасдсаар байлаа. Харин Марк Александрович тэгж санахгүй байв. Сёмушкин дээд түвшинд зөвхөн эргэлдэж байгаа бол мань эр энэ түвшинд хөдөлгөж байгаа хүн. Тийм учраас Сёмушкиний нарийн бичгийн даргархсан санаархал түүнд садаа болох ёсгүй.

Тэрээр уужуу тайван байлаа. Гагцхүү үсчний газрын хөндлөнгийн үнэр л саад болж байв. Ийм ариухан байдалтай Кремльд, Сталин руу очно гэдэг мулгуу хэрэг. Мань хүн үсчинд дахин очиж толгой түрүүгээ мулз угаав. Үсчин сандал дээр байгаа хүнээ орхичихоод Марк Александровичийн өмнө алчуур барин зогсоно. Хагасхан цагийн өмнө өөртэй нь халзарч яваа эрэгтэйчүүдийн тухай тоглоом болгон ярьж байсан нөгөө хээгүй Марк Александрович нэгэнт өөрчлөгджээ. Эзэрхэг царай нь ялангуяа нүдний шилгүй байгаа үедээ бүр ч өршөөл

энэрэлгүй харагдана.

Марк Александрович явсаар Троицкийн хаалга руу очиж үүдний жижигхэн цонхоор намын батлахаа үзүүлэв. Цонх хаагдсанаа дахин нээгдэж, шилний цаана цэргийн хүний бараа зурсхийж цонхоор шагайваас Марк Александрович сая түүнийг тогтож харлаа.

–Танд зэвсэг бий юү?

–Байхгүй

–Цүнхэнд чинь юу байна?

Марк Александрович цүнхээ өргөөд нээж харуулав.

Жижүүр түүний намын батлахын завсар пропуск хавчуулан буцааж өгөв.

Тусгай орцны үүдэнд винтов буутай хоёр байлдагч зогсчээ. Харуул намын батлахынх нь зургийг анхааралтай харснаа нүүр рүү нь албаны гярхай харцаар нэгэнтээ сонжин ширвэв. Марк Александрович хувцсаа авсаархан өлгүүрийн тэнд өлгөчихөөд гурван давхарт гарлаа. Тасалгааны үүдэнд энгийн хувцастай нэг хүн бичиг баримтыг нь дахин шалгав.

Ажлын цэлгэр өрөөнд Поскрёбышев ширээний ард сууж байв. Марк Александрович түүнийг анх удаа харж байгаа нь энэ бөгөөд яасан ширүүн нүдэнд хүйтэн царайтай юм бэ гэж бодов. Рязанов нэрээ хэллээ.

Поскрёбышев түүнийг дараачийн хүлээх өрөө рүү дагуулан орсноо өөрөө цаашаа орж хаалгаа сайн татаж хаалаа. Дараа нь буцаж ирээд,

–Нөхөр Сталин таныг хүлээж байна гэв.

Сталины ажлын өрөө том, цэлгэр урт ажээ. Зүүн гар талын ханан дээр ЗСБНХУ-ын нэг их том газрын зураг өлгөөтэй байна. Баруун гар талд цонхнуудын хоорондох зайд номтой шүүгээнүүд тавьжээ. Наад талын буланд тавиур дээр том глобус, алсын буланд ардаа олбогт сандалтай бичгийн ширээ байна. Тасалгааны голд ногоон цэмбэн бүтээлэгтэй урт ширээ, сандлууд байна.

Сталин өрөөн дундуураа нааш цааш холхиж байснаа хаалга нээгдмэгц зогтусав. Тэрээр бараг бор өнгийн хамгаалалтын материалаар хийсэн френч цамцтай, мөн тийм өмднийхөө шуумгийг савхин гуталдаа дарж өмсжээ. Дунд зэргийн нуруутай хүнээс чацаар нам юм шиг санагдах боловч чийрэг бадриун, яльгүй монголжуу нүдтэй, цоохордуу нүүртэй аж. Нарийхан магнай дээр хөвсийх өтгөн үс нь бууралтах аяс оржээ. Сталин Марк Александровичийн өөдөөс хэд хөнгөхөн алхаад гараа өгөв. Энэ нь энгийн түвшин байдлыг илтгэвч Сталин ийнхүү гар барьж байгаагийнхаа ач холбогдлыг ухамсарлаж буй нь тодорхой. Дараа нь ширээний араас хоёр сандал татаж гаргав. Тэр хоёр суулаа. Марк Александрович Сталины нүдийг тун ойрхноос харж таарсанд цахилсан цийлгэр бор нүд нь хөгжилтэй ч юм шиг санагдав.

Марк Александрович барилгын ажлын ерөнхий байдлыг тайлбарлан илтгэж эхлэв. Сталин тэр даруй яриаг нь тасалж,

–Нөхөр Рязанов, цаг битгий гарзад. Барилга хаа барьж байгаа, яах гэж барьж байгааг Төв Хороо, түүний нарийн бичгийн дарга мэднэ гэв.

Тэрээр илт гүрж аялгатай ярих ажээ. Барилга байгууламжийн явцын талаар сайн мэдэж байгааг нь Марк Александрович бүрэн ухаарлаа.

–Комсомолчид зугтаж байна уу?

–Тийм

–Тэгвэл зугтаалгах гэж дайчилсан байх нь ээ! Олон хүн зугтаасан уу?

–Наян хоёр хүн

Сталин харц нэвт шувт сонжин харах аж...

–Танилцуулгаа үзүүл дээ.

Марк Александрович цүнхнээсээ ажиллах хүчний хөдөлгөөний хүснэгтийг гаргаж зохих хүснэгтийг үзүүлэв.

–Нөхөр Рязанов та яагаад өөрийгөө гүжирдээд байна?! Хэрэв аль нэг заводуос наян хоёрхон хүн зугтсан бол тэр заводын дарга баатар шиг бардам байх байлгүй.

Тэрээр инээмсэглэв. Хоёр нүдийг нь тойрсон үрчлээс илт тодроод явчихлаа.

Марк Александрович тоног төхөөрөмж нийлүүлж байгаа заводын талаар гомдол мэдүүлэв. Сталин тэр заводын дарга хэн болохыг асуув. Нэрийг нь дуулаад,

–Ухаантай хүн биш, хамаг ажил нураачихна гэв.

Түүний нүд гэнэтхэн барынх шиг шаргалтан гөлийж, нөгөө хүнийг заных мэт гялсхийв. Марк Александрович тэр даргыг хүнд нөхцөлд орчихсоноос биш сайн ажилтан гэж санадаг ажээ.

Рязанов хамгийнхаа ярвигтай асуудалд орлоо. Тэр нь мартен зуухны хоёрдугаар цехийг барих асуудал.

–Нэг жилийн дотор барьчих уу?

–Үгүй ээ, нөхөр Сталин.

–Яагаад?

–Би техникийн балмад явдалтан биш.

Тэгж хэлэнгүүтээ хэлсэн юмнаасаа айчихав. Сталин түүнийг анхааралтай ширтэн харлаа. Нүд нь дахиад л шарлан гөлийж, нэг хөмсөг нь хөндлөн болчихов. Тэрээр үгээ сунжруулан зөөж,

–Тэгвэл Төв Хороо техникийн балмад явдалтан байх нь ээ? гэж асуулаа.

–Би буруу хэлчихлээ, та уучлаарай. Би ингэж хэлэх гэсэн юм.

Мартен зуухны цехийн хоёрдугаар ээлжийг яагаад ирэх онд дуусгаж болохгүйг Марк Александрович тодорхой үнэмшилтэй илтгэв. Сталин сайн тэнийдэггүй юм уу гэлтэй гаанс атгасан солгой гараа цээжиндээ наан анхааралтай сонслоо.

–Та шударга ярилаа. Юу ч байсан амлаж байдаг коммунистууд бидэнд хэрэггүй. Үнэнийг хэлдэг коммунистууд бидэнд хэрэгтэй.

Сталин үүнийг инээд мишээлгүй тун дорвитой хэлсэн нь нийт улс даяарт зориулагдсан болой. Марк Александрович үргэлжлүүлэн илтгэх гэтэл Сталин тохойд нь хүрч,

–Би таныг сонслоо, одоо та намайг сонс гэв.

Тэрээр төмөрлөгийн үйлдвэрийн тухай, Дорнодын тухай, хоёрдугаар таван жилийн тухай, улс орныг батлан хамгаалах тухай ярилаа. Намуувтар дуугаар аажуухан, зөөлхөн бөгөөд бичээчид дуудан өгч байгаа мэт тодхон ярина. Нийтээр мэдэх юмыг ярьж байгаа боловч одоо түүнийг сонсоход шинэ, гойд жинтэй мэт санагдана. Харин Марк Александровичийг элдвээр татгалзахаас болгоомжилсон мэт дөрөвдүгээр зуухны талаар юу ч дурссангүй. Хэрэв Марк Александрович зөрвөл Сталин хүлээж авахгүй, тэгвэл зөрсөн хүнд л муу юм болох билээ.

–Та хэзээ буцах вэ? гэж Сталин босох зуур асуув.

–Өнөөдөр гээд Марк Александрович мөн босов.

–Хэрэв бололцоотой бол хоёр хоногоор хойшлуулахгүй юу. Таныг Улс төрийн Товчоон дээр сонсоход нөхдөд сонин болно гэж би санаж байна

Сталинтай ярьж байхад Марк Александровичийн сэтгэл түгшин нэг л хачин оргиод байсан нь зүгээр болж аугаа их юманд шүргэсний бишрэлийн сэрэл үлдэв. Түүний бариулж байгаа жишиггүй нүсэр барилга байгууламжийн ажлыг явуулахад төмөр мэт зориг хэрэгтэй. Дээд талд нь Сталины төмөр мэт зориг байгаагүй бол мань хүн ч өөрийнхөө зоригийг тэгж гаргаж чадахгүйсэн. Сталины дур зориг тун чиг хатуу билээ. Яая гэх вэ дээ! Түүхэн эргэлтүүдийг зөөлөн сэтгэлээр хийдэггүй юм чинь.

Ардын комиссарын газрынхан Марк Александровичийн Сталинтай ярьсан зүйлийг мэдсэн тул холбогдох хүмүүс хэдийн Улс төрийн Товчооны шийдвэрийн төсөл хийгээд эхэлжээ. Ерөнхий газрын ажилтнууд, бичээч, буфетны үйлчлэгч гээд орой, шөнө хэрэг болох хүмүүс цөм ажил дээрээ үлдэв. Шийдвэрийн төсөлд санал өгсөн байвал зохих коллегийн гишүүд утсаар дуудмагц Ардын комиссарын газар ирэх ёстой, тэгээд баримт бичгүүдийг өглөө гэхэд

Төв Хороонд бие хүн авч очно.

Сталины юу ярьсныг Марк Александровичаас нэг ч хүн асуусангүй. Дам яриа ямар нэг юмыг гажуудуулж магад. Сталин хэрэгтэй гэж үзсэн зүйлээ өөрөө ард түмэндээ ярьдаг шүү дээ. Марк Александрович хугацаа, барилга байгууламжийн нэрийг л хэлсэн, чухамдаа энэ бол Сталины таалал билээ.

Хоёрдугаар цехийг барьж дуусгах хугацааг нэг жилээр хойшлуулсан явдал гол юм байлаа. Металл бүх юмны үндэс учраас ийнхүү хойшлуулсан нь хоёрдугаар таван жилийн төлөвлөгөө зохиоход шинээр, бодитойгоор хандах бололцоог бий болгож байгаа хэрэг.

Будягин шийдвэрийн төсөл боловсруулахад мөн оролцож байснаа явчихаад өглөө найман цагт ирж үг дуугүй зөвшөөрсөн санал өгөв.

Будягин Марк Александровичтай үерхдэгийн хувьд ярианы тухай асуувал асуух л байсан. Будягин асуусангүй. Түүнд Сталины эсрэг санаа бий гэдгийг Марк Александрович таамаглаж байлаа. Гэхдээ энэ нь улс төрийн зөрөлдөөн биш гэдэгт өчүүхэн төдий ч эргэлзээгүй. Их л бодож хувийн ямар нэгэн юм байгаа. Найзлахаа больсон нөхдийн харьцаа тиймэрхүү байдаг шүү дээ. Хилийн чанадаас эргүүлэн дуудаж, дээгүүр ч гэсэн хоёрдугаар зэргийн албан тушаалд томиллоо гэж гомдсон байж болох юм. Энэ албан тушаал нь бүр жижиг тушаалд шилжих нэг шаг ч байж мэднэ.

Оржоникизе ирэв ээ. Марк Александрович илэн далангүй өөриймсөг байдаг хүн чухам тэр билээ. Оржоникизе их ууртай, хуйхалж мэдэх хүн гэхдээ тэр нь дорхноо арилдаг, өрөвчхөн сэтгэлтэй гэдгийг бүгд мэднэ. Өмнө зүгийн нэгэн жижигхэн заводын дарга байхад нь өнөөгийн энэ албан тушаалд дэвшүүлж, улсын гол металлургич болгосон болохоор Марк Александровичийн хүү дээгүүр яваа нь Оржоникизегийн ач билээ. Серго хэрэгтэй хүнийг олж чаддаг, түүнийг хамгаалдаг, ажиллах боломж олгодог хүн.

Тэрээр нүсэр том бичгийн ширээний ард сууж байв. Сэлхэрсэн нүүртэй, махлаг бүргэдэн хамартай, буурал суусан халмигтай, өтгөн хирнээ урт богино юм шиг сахалтай ядарсан царайтай эр. Кителлийнх нь дээд талын товч задгай, цаанаас нь цухуйх ягаан цамцны намхан зах махлаг хүзүүнд нь эвтэйхэн наалдана. Тасалгааных нь цонх нарийхан хөндлөн гудмын хуучны бяцхан сүм рүү харжээ. Ийм сүм олонтой Яуза, Солянка, Москва голоор хашигдсан Москвагийн хуучин энэ гудамжинд энэ бяцхан сүмийг газрын хөрснөөс арчилгүй үлдээсэн байхыг бодоход аль нэг байдлаараа дурсгалтай байсан юм байлгүй.

—Эр хүн!

Энэ магтаал Улс төрийн Товчооны шийдвэрийн төсөлд ч хамаатай, Сталины өмнө Марк Александрович мэгдэж сандралгүй таашаалд нийцсэнд ч хамаатай байв. Бас өөрт нь ч хамаатай байжээ. Юу гэвэл, сайн хүн шилж авч чадсан, ер нь төвөгтэй, хариуцлагатай нөхцөлд бүрэн найдаж болох хүмүүсийг сонгон авч чаддаг хүн.

—Яригтун!

Марк Александрович болсон яриаг ярьж өгөв. Оржоникизе Сталины үг болгоны чин санааг ухааран ойлгохыг оролдох мэт чих тавин сонсов.

Сталинтай уулзсан нь холдох тутам Марк Александровичид энэ явдал улам сүртэй болж байх шиг санагдана. Ийм уулзалт энэ яваа насанд нэг л тохиолдоно. Суу билгээрээ эрин цагаа гийгүүлсэн аугаа их хүнийг ухааран ойлгосондоо л баярлахын гол учир байлаа.

–Би техникийн балмад явдалтан биш... Яг тэгж хэлсэн үү? Хэмээн Оржоникизе инээд алдаж асуув.

–Яг тэгж хэлсэн

–Тэгвэл Төв Хороо техникийн балмад явдалтан байх нь ээ? гэж Оржоникизе дахин инээд алдаж давтан асуув.

–Яг тэгж асуусан

Оржоникизе бүлтгэрдүү том бор нүдээрээ түүнийг тун нухацтай ширтэн харав.

–Төв Хороо руу аравт очно шүү. Илтгэл таван минут, илүү хугацаа өгөхгүй, үүнийг бодолцоорой. Зөвлөлт засгийн төлөө ухуулаад байхын хэрэг байхгүй, чамд юу хэрэгтэйгээ л тодорхой яриарай. Асуусан юманд нь л хариулаарай, хөндлөнгийн үгийг тоохын хэрэггүй. Биеэ битгий бариарай, намайг цуг байгаа л гэж бод!

Илтгэл тавих хүмүүсийн өрөөнд ширээн дээр ус нь буцалж байгаа халуун тогоо, хэрчсэн нимбэг, хачиртай талх, лонхтой рашаан зэрэг тавиастай. Буфетны худалдагч, үйлчлэгч хүн гэж алга. Ханын дагуу болон цонхны дэргэд материал бичиж бэлтгэхэд зориулсан бичгийн авсаархан ширээнүүд байна.

Мужийн намын хорооны нарийн бичгийн дарга нар, ардын комиссар тэдгээрийн орлогчид, ерөнхий газрын дарга нар, цэргийн хэдэн дарга, Кавказаас ирсэн хэсэг хүмүүс хэзээ дуудахыг хүлээж байна.

Нарийн бичгийн дарга настай авгай “Нөхөр тэр... хуралд орно уу” гэж зарлана.

Хэрэв хэсэг хүнийг бөөнд нь дуудаж байгаа бол тэрээр “Тийм мужийн нөхдүүд” гэх буюу “Тийм ардын комиссарын газрын нөхдүүд” гэж хэлнэ.

Марк Александровичийг овгоор нь дуудлаа.

Тэрээр нарийн бичгийн дарга нарын ажиллаж байсан өрөөг дамжин хурлын тасалгаанд ормогц эгнүүлэн тавьсан олбогт сандлууд дээр сууж байгаа хүмүүсийг үзэв. Тэргүүлэгчдийн ширээний ард Молотов зогсоно. Түүний баруун гар талд индэр, зүүнтэйхнүүр архан талд нь туслах нь, түүнээс зүүн тийш хурдан бичигч бүсгүйчүүл сууцгаажээ.

–Нөхөр илтгэгч, наашаа ирнэ үү!

Молотов индэр рүү заав. Дотор талд нь “Илтгэгчид таван минут” гэсэн гэрэлтэй самбар байх аж. Индрийн эсрэг талд хаалганы дээр Кремлийн цагтай төстэй алтан зүүтэй хар цаг өлгөөтэй байна.

Сталин гуравдугаар эгнээнд сууж байв. Түүнээс зүүн тийш эгнээгээ дуустал сандал эзэнгүй байгаа нь тэрээр чөлөөтэй гарч болно гэсэн үг. Сталины тасалгаан дундуур холхих зуршилтайг Марк Александрович дуулсан билээ. Харин энэ удаа Сталин цаад өдрийнх шигээ боссон ч үгүй, нааш цааш холхисон ч үгүй.

Марк Александрович шийдвэрийн төслийг товчхон тайлбарлав. Тэрээр улс төрийн ярианд дассан хүмүүст үнэмшилтэй техникийн хэлээр товч тодорхой ярилаа. Дөрөвдүгээр зуухыг хугацаанаас нь өмнө оруулах гэж байгааг цохон тэмдэглээд мартен зуухны цехийн хоёрдугаар ээлж хойшлогдож байгааг цухас дурдах төдийгөөр өнгөрөв. Сүүлчийнх нь нэгдэхээс чухал зүйл. Гэвч өнөөдөр энд чухам Марк Александровичийн цохон дурдсаныг онцлох нь чухал.

–Асуулт байна уу? гэж Молотов асуув.

Шийдвэрийн төслийн мод нийлүүлэх тухай хэсэгт Ойн аж үйлдвэрийн ардын комиссарын газрын зөвшөөрөл алга гэж нэг хүн хэлэв.

Марк Александрович хариулж амжсангүй. Гэнэтхэн нам гүм болоод явчихсан чинь мань хүнд Сталины дуу сонсогддог байна.

–Нөхөр Рязанов комбинат руугаа очиж металлаа гаргаг. Нөхөр Рязановыг цаас төдийхнөөр саатуулах нь буруу хэрэг болох юм...

Тэрээр өөрийнхөө үгийг сонсох гэж бусдыг албадан хүчлүүлж тэс өөр тийшээ харчихаад маш аяархан ярих ажээ.

–...Бид нөхөр Рязановгүйгээр холбогдох зөвшөөрлийг авч чадна гэж би бодож байна. Бодож боловсруулсан шийдвэр байна, элдэв муу юм нэхээгүй байна, тийм учраас намын даалгаврыг биелүүлэхэд нь нөхөр Рязановт бид тусалж чадна.

Сталин яг эхэлсэн шигээ гэнэтхэн чимээгүй болов.

Өөр хэн ч асуулт тавьсангүй.

Хувьсгалын өмнө ямбатных байсан Арбатын нэг байшинд айлуудыг шахаад оруулчихсан тул одоо хамгийн олон айлтай байшин болжээ. Гэхдээ зарим айл хуучин хэвээр олон өрөөтэй үлдэж чадсан нь хотын бэртэгчингүүдээс нийгмийн шинэ байгууллыг давсан бяцхан ялалт юм. Ийнхүү ялагчдын дотор нь оёдолчин Шарок байсан хэрэг.

Шарок маяг гоё хувцас оёх газрын гар хөлийн үзүүрийн бандиас эсгүүрчин, мастер, тэгээд эцэст нь эндхийн эзний ганц охины нөхөр хүртэлх эрх тушаалын замыг туулсан ажээ. Энэ зам оёдлын газрыг өвлөж авснаар дуусах байсан боловч хувьсгал саад болж түүнийг нь улсынх болгожээ. Шарок оёдлын үйлдвэрт ажиллаж хажуугаар нь гэрээрээ юм оёж ашиг хонжоо олдог болов. Гэвч тэрээр санхүүгийн хянан байцаагч нартай хэзээ ч тааралдахгүй хэмээн ихэд болгоомжлох тул маш найдвартай хүнээр дамжуулж ярихаас нааш мань хүнээр юм оёулах арга байхгүй.

Түүнээс гадна энэ оёдолчин дунд зэргийн бялдтай, цэх нуруутай, эмэгтэйчүүдийн хувцас хэрэглэлийн эзний ёсорхог намба төрхтэй, сайхан толиотой өтөлж яваа эр билээ. Долоо хоногийн зургаан орой хүзүүн дээрээ хулдаасан метр тохчихоод ширээний ард материал дээр эсгүүрийнхээ ормыг бүдэгхэн зурж, эсгэж, оёж, оёдлоо индүүдэж зогсоно. Мөнгө олж байгаа нь тэр. Морины уралдаанд мөрийцөх ясны хорхойтой, ням гаригийг морин тойруулгад өнгөрүүлнэ.

Орон сууцны захиргаа, айл хөршийнхөн болон элдэв санамсаргүй хэрэг явдлаас хэзээ ямагт айж байдаггүйсэн бол хөгшин Шарок аж амьдрал, хувь тавилантайгаа эвлэрэх байсан биз. Их хүү Владимир нь алт мөнгөний дэлгүүр тонож байж шоронд найман жилээр заагдсан нь санамсаргүй явдлуудын нэг билээ. Эхийгээ дуурайсан болохоор сармагчинтай адилхан тэр болчимгүй толгойтод мань хүн урьд нь ч итгэдэггүй байсан. Гэвч Владимир “Прага” рестораны дэргэдэх тогоочийн сургуулийг төгсөөд гэртээ цалин авчрах болсныг нь их юм гэж боддог байжээ. Одооны тогооч хуучин цагийнханд хаана ч хүрэхгүй нь мэдээж, одооны рестораны байж байгаа царайг! Гэхдээ бие бялдар дорой, ном хичээлд авьяасгүй Владимирт мэргэжлийг нь азтай сонгосон хэрэг. Морин уралдааны мөрий хөөсөөр байгаад өвгөн Владимирийн мөрийтэй хөзөрддөгийг нь төдийлэн тоодоггүй байжээ. Харин тонуул дээрэм хийнэ гэж юу гэсэн үг вэ? Энэ бол зөвлөлтийнх битгий хэл ямар ч хуулиар гяндан шүү дээ.

Шарокийн бага хүү Юрий бол Москвагийн хүний адаг шаар үүрлэсэн Смоленский зах, Проточный хөндлөн гудамнууд гээд Арбатын хороололд өсөж торнисон нямбай даруу, зальжин хянуур хөвгүүн юм. Ахынхаа хулгай хуудмаар аж төрж байгааг гадарладаг ч гэсэн гэрийнхэндээ юу ч ярьдаггүй, байгаа нийгмийнхээ хууль ёсноос урьдаар гудамжны хууль ёсыг дагах илүү дуртай нэгэн аж. Тэрээр хувьсгал өөрт нь чухам ямар хохирол учруулсныг мэдэхгүй хэрнээ ямар ч байсан хохирол учруулсан гэдэг үзэл хар багаас нь толгойд нь шингэжээ. Өөр нийгэмд яаж аж төрөх байснаа эс төсөөлөвч ямар ч байсан дээр амьдрах байсан гэдэгт үл эргэлзэнэ. Шинэ амьдралын эздийг тэдний гэрийхэн ад үзэн ёгтолж нөхөд хэмээдгийг тэрээр сургуулийнхаа комсомолын гишүүдийг нэрлэх үг болгожээ. Тэр шазруун идэвхтнүүд орчлон дэлхий өөрсдийнх нь өмч мэт авирлана. Тэгэхэд сургуулийн комсомолын үүрийн нарийн бичгийн дарга байсан Саша Панкратов индэр дээр гараад хурц тодорхой ярьж

эхлэхэд Юра өмгөөл, ивээлгүй мэт хөөрхий болдог билээ.

Тэрээр улс төрийг үзэн яддаг, инженерийн мэргэжлийг яльгүй ч гэсэн эрх зоргоороо байх нөхцөл олгох цорын ганцхан боломжийн зүйлд тооцно. Энэ төлөвлөгөө нь бас л ах нь баривчлагдсантай холбогдсон нэгэн тохиолдлоос болж өөрчлөгджээ. Хөгшин Шарок өмгөөлөгч хайж, захиалга өгдөг хүмүүстэйгээ зөвлөлдсөөр эцсийн бүлэгт таван зуун рублиэр хийхийг зөвшөөрсөн нэг өмгөөлөгч олжээ. Энэ бол маш их мөнгө. Шарок тийм мөнгийг гэрчгүй өгөхөөсөө болгоомжлон Юрийг дагуулж очжээ. Өмгөөлөгч багц мөнгийг тоолж ч үзэлгүй, ширээнийхээ нүдийг татаад тийш нь тоомжиргүй хаячихжээ. Тэр хоёрын айлчлал үүгээр дууссан боловч Юрий алталсан жаазтай уран зургууд, шүүгээний шилний цаана байгаа алтан үсэгтэй номуудыг олж харж амжжээ. Тэрээр ийм юм хараахан үзээгүй билээ.

Хөгшин Шарок гадаа гарсан хойноо,

–Хүмүүс ч аж төрж чадах юм даа... хэмээн атаархан санаа алджээ.

Гэтэл сайхь өмгөөлөгч шүүхийн хурал дээр Юрад улам илүү сэтгэгдэл төрүүлжээ. Эрүүндээ бага шиг цэвэрхэн сахалтай үрчгэр нүүртэй энэ давжаа эр пролетарийн догшин шүүхийг санасан зүгтээ мушгиж байлаа. Ямарч атугай залуу Шарокт л тэгж байх шиг санагджээ. Тэр өмгөөлөгч хуулийн зүйл ангиудыг цувруулан урсгаж, элдэв ов мэх, арга чарга сүвэгчлэн, гэрчийн шинэ этгээдүүдийг шаардан олуулж, хэргийн байдалд дахин шинжилгээ хийлгэж, шүүгч, прокурор хоёрыг ёж үгээр утаж хэдэрлэнэ. Албархаг шүүгч, гэтэлшгүй прокурор хоёрын мэдэлд хууль ёс байгаа хэрнээ өөрсдөө түүнээс айгаад байгааг залуу Шарок олж мэдсэн нь амьдралынх нь төлөвлөгөөг тодорхойлсон нээлт болжээ. Өмгөөлөгчийн албанд хүрэх зам дээд сургуулиар дамжина, дээд сургуульд хүрэх зам комсомол, үйлдвэрээр дамжина.

Тийнхүү Юрий Шарок есдүгээр ангид комсомолын гишүүн болов. Арбатын сэхээтний хүүхдүүд голлосон сургуульд ажилчны хүүхэд өндөр үнэлэгддэг болохоор мань хүн ажилчны хүү хэмээн биеэ даасан шинжтэй байдаг нь охидод нэг л учир битүүлэг санагддаг байжээ. Ялангуяа ухаалаг, юм боддог, идэвхтэй охид түүнд сүйд болно. Охид түүнийг хүмүүжүүлж, хувь хүнийг бүрэлдүүлж байгаа юм шиг өөрсдөд нь санагдана. Энэ төлөв сайхан залуу тэр гэнэн цагаан сэтгэлтэй охидын нүдийг гойд татдаг байжээ.

Шарок дараа нь үйлдвэрт ажиллаж байхдаа урьд өмнө үгүйлэгдэж байсан өөртөө итгэх итгэлийг олж авчээ. Ажилчин! Дандаа цэвэрхэн байдаг ажлын хөх хувцас өсгөлөн биед нь сайхан зохино. Ажилчны хээгүй зан нэрийдлээр дэндүү сэхээтэн занг өширхөх, зарчимч байдал нэрийдлээр муйхарлах зэрэг зантай боллоо. Сургуульд үг дуугүй, даруухан байсан хүн чинь нийтийн өмнө юм ярьж сурах нь хожмын өмгөөлөгчид хэрэг болно хэмээн зүйтэй ухаарч одоо болохоор хурал дээр үг хэлэх нь элбэг.

Шарок дээд сургуульд байхдаа ямар нэг гайхуулах юм байсангүй, гэхдээ олон нийтийн ажилд оролдлого зүтгэлтэй хүн гэдгээ харуулжээ. Өөрөө ч аль нэг юмаар бусдаас ялгарахыг бодсонгүй. Хорлон сүйтгэгч, ажил санаатай саатуулагч, нугалаа гаргагчийн тухай мэдээ сэлт сониноор дүүрэн байх. “Хэргийг нь уудлан илрүүлье! Хайр найргүй залхаая! Хөөн дотортнууд! Устгая! Гүйцэж дарья! Үндсээр нь үгүй хийе! Үндэс хорыг нь тасалъя! Газрын

хөрснөөс арчъя!” Шарок энэ үгс, энэ товчхон авч хаагуур нь ч гарахын аргагүй үг хэллэгээс буун сум мэт айна. Тэрээр бүх юмны учрыг сайн ойлгож, бүх юмыг сийрэгхэн цэгнэн үзнэ. Дээд сургууль төгссөнийх нь дараа муж руу, районд, ардын шүүхэд буюу прокурорын газар явуулна. Өмгөөлөгч болох санаатай тухайгаа мэдээж үг ч цухуйлгахгүй. Хэрэв цухуйлгавал хариуд нь “Шарок, чи зайлсхийж байна шүү!” гэсэн үг л сонсоно. Тэгж шаргуу тэмүүлж яваа зорилгоос үнэхээр ухрахад хүрнэ гэж үү дээ?

Эцэг нь Юрад костюм хийж өгөв. Өмд нь урт өргөн шулхнагтай, пиджак нь бэлхүүсээрээ нарийн, мөр нь товхгор, энгэр нь зөөлөвтэй богиновтор хийцтэй, хамгийн сүүлчийн “чарльстон” хэмээх маяг. Цэнхэр нүдэн Юра энэ костюмаа өмсчихлөөр тун дориун харагдана. Даавууг нь Тверийн гудамжны торгсиноос[4] худалдаж авсан ажээ.

–Арбатын торгсинд айл хөршийнхөн чихэлдэж өлөн нүдлээд байцгааж байгаа. Тэд нар чинь Шарокийнх алтаа дарсан улс гэж хэлнэ, зажлахгүй залгиж, дүлэхгүй гаргах улс шүү дээ гэж эцэг нь өгүүлжээ.

Өвгөн алтан бугуйвч, алтан чагтан товчнууддаа хичнээн харуусаж байсан боловч Москвад олигтойхон газар ажилд орохын тулд аятайхан хувцасласан байх хэрэгтэйг ойлгож байжээ. Харин ч савхин хүрэм, давуулж товчилдог захтай цамцны үе өнгөрөөд байгаа нь яамай. Хэдийгээр хар амиа бодож гэр орон, үр хүүхдээ хайхардаггүй ч гэсэн Шарок бага хүүгээ өөрийнхөө залуу байхтай зүйрлэн түүнд эцэг хүнийхтэй төстэй сэтгэлээр ханддаг байжээ. Юрийг Москвад суулгахын тухайд бол өвгөн үнэхээр сонирхож байжээ. Учир юу гэвэл орон сууцны захиргаа тэртэй тэргүй хоёр дахь өрөөг нь илүү үзээд байгаа юм чинь. Юрийг гараад явчихвал тэр өрөөг дор нь хураачихна.

–Танил тал хэрэгтэй, танил талтай болж үзээрэй гэж тэрээр Юраг сургамжилна.

Гэвч Юрий үйлдвэрээс ч, дээд сургуулиас ч найзтай болж чадаагүй. Нөхдөө гэртээ дагуулж ирэх хориотой. Хамаатан садангууд нь ядуу зүдүү, дараа болохоос өөр юмгүй тул гэртээ ч урьдаггүй, өөрснөө ч очдоггүй аж. Чөлөөт цагаа эцэг нь морин тойруулгад, эх нь сүмд барна. Хүүхдүүдээ улаан өндөгний баяраар нарийн талхны булан, шар тосны баяраар хуймаг хийж өгснөөр баярыг цэглэх нь тэр. Хөгшин Шарок бурхныг үл шүтэх агаад хоосоорсныхоо бурууг бурхан хэмээн өширхөнө. Зөвлөлт засагт түүнээс ч илүү өширхөн Майн нэгэн, Октябрийн баяраар ердийн өдөр шиг ажиллана.

Сургуулийнхаа нөхөдтэй тогтоосон холбоо л хамгийн тогтвортой нь болж таарчээ. Юрагийн байшинд тэдний ангийн гурван хүүхэд байдаг билээ. Саша Панкратов - сургуулийн комсомолын үүрийн нарийн бичгийн дарга, Максим Костин - цахилгаан шатны авгайн хүү, нөхөд нь түүнийг Макс гэнэ. Нина Ивановна гэдэг уяхан сэтгэлтэй комсомолын гишүүн, Шарокийн хүмүүжилд нөлөөлсөн хүний нэг. Бас нэрт дипломатын охин Лена Будягина тэр хэд нийлээд сургуулийн идэвхтний эв нэгдэлтэй бүлэг байжээ. Зөвлөлтүүдийн тавдугаар байшинд Ленагийн цугларна. Будягин гадаадад сууж байсан учир байрыг нь хүүхдүүд эзэгнэдэг аж. Юра тэднийхээр очихдоо иймэрхүү хэлхээ холбоо хэрэг болно гэдгийг бүдэг бадагхан ухамсарлана. Тэр бүдэг бадаг ухамсар нь өнөөдөр бодитой найдлага болж хувирчээ. Хилийн чанадаас дуудагдаж, Хүнд аж үйлдвэрийн ардын комиссарын орлогчоор томилогдсон Будягин түүнд тус болж чадна.

Юра Воздвиженкаас Грановскийн гудамж руу эргэв. Энд саарал боржингоор өнгөлсөн Зөвлөлтүүдийн тавдугаар байшинд тэд нар аж төрнө. Суман зэвтэй төмөр хайсаар хүрээлсэн бяцхан цэцэрлэгт тэдний хүүхдүүд тоглоно. Хаалгач өвгөн Будягиных руу утасдаж байх зуур Юра орцонд гудиггүй царайлан зогсов. Тэгээд гурван давхарт гарч товчлуурыг дарлаа.

Лена хаалга онгойлгож өгөөд урьдын адил ичингүйрсхийн инээмсэглэв. Тэрээр чац өндөр учраас өтгөн үстэй толгойгоо арга буюу гудайсхийнэ. Гонзгойдуу хөрслөг сайхан цагаан царайд нь улаан ягаан өнгийн паравгардуу уруултай ам нь арай томдсон гэлтэй. Ленаг хажуунаас нь харахад дорнын дагинын дүрстэй гэж нэг удаа Нина хэлж байсан билээ. Үнэндээ дорнын дагина гэж юу байдгийг Юра мэдэхгүй ч гэсэн Лена Будягина сургуульдаа хамгийн хөөрхөн охин гэдгийг сайн мэднэ.

Юрий хуучин танилын хээгүй байдлаар бүсгүйг өөр рүүгээ татав. Цаадах нь дургүйцсэнгүй.

–Хүүхдүүд ирсэн үү?

–Үгүй л байна

–Иван Григорьевич бий юу?

Лена түүнийг шинэхэн зүлгэсэн шалны үнэр ханхалсан хонгилоор эцгийнхээ өрөө рүү дагуулж ирээд,

–Аав аа, Юра тантай уулзах гэж ирлээ гэв.

Тэгээд Шарокийг өмнөө оруулаад аз жаргалтай үнэнч инээмсэглэлээр мишээв.

Гаднах ханынх нь товгор чулуу цонхны тэн хагасыг халхалснаас болж нарийхан өрөөнд гэгээ муутай ажээ. Орос болон гадаадын ном, сонин, сэтгүүл, танилцуулгууд ширээ, номын тавиур, сандал, шал энэ тэрээр хөглөрөн хэвтэнэ. Усан онгоцны замыг тасархай шугамаар тэмдэглэн эрээлсэн дэлхийн бөмбөрцгийн хоёр талын газрын зураг жижигхэн орны дээр өлгөөтэй байна. Юра Будягины хааж хажуу тийш нь тавьсан албан сэтгүүлийн гурван оронтой дугаарын хар тоог анзаарав. Тэр бол зөвхөн Төв Хороо, Төв шалган байцаах комиссын гишүүдэд тараадаг нууц баримт бичиг юм. Гадаадын “Паркер” үзэг, “Тройка” янжуур, каучук ултай шаахай, нэрд гарсан Энтин гэгч оёдолчин дээд зиндааны дипломатуудад оёж өгдөг пиджак энэ тэр байхыг Юра мөн ажиглав.

Будягин өөрт нь хүсэлт тавьдагт дасчихсан болохоор,

–За юу гэв? гэж ердийн тайван байдлаар өгүүлэв. Хар сахалтай хатингар царайтайн дээр хөмсөг нь өтгөн болоод ч тэр үү, нүд нь Ленагийнхаас ч хөнхөр юм шиг харагдана.

–Иван Григорьевич, би зөвлөлтийн хуулийн дээд сургууль төгсөж байна. Гэтэл ах маань ял эдэлж байгаа...

Хонх дуугарч, хаалга нээх чимээ сонсдов.

–Шүүх, прокурорт намайг авахгүй, тэгэхлээр аж ахуйн хууль эрхийн ажил цаана нь байна. Үйлдвэрт л очмоор байх юм. Дээд сургуульд орохынхоо өмнө би Фрунзийн нэрэмжит үйлдвэрт ажиллаж байсан. Хүнээ ч танина, үйлдвэрлэлийг ч мэднэ.

Будягин Юраг тоомжиргүй харцаар зэрвэсхэн харав. Бусдыг удирдах эрхтэй гэдэгтээ итгэсэн нь илт. Юра болон Юра шиг хүмүүс түүний хувьд юу сан билээ? Тэд нар бол олон түмнийг удирдаж, олон түмний хувь заяаг шийдэж дассан улс.

–Чи Эгерт дээр очоорой. Би түүнд хэлэмз

–Баярлалаа, Иван Григорьевич

–Ах чинь ямар хэргээр орсон юм?

–Эрүүгийнх. Хүүхэд л дээ, үл бүтэх юмнуудтай нийлчихсэн юм.

–Бид хуучин хууль зүйчдийг тарааж хөөсөн, гэтэл шинэ маань мэдлэг багатай байна. Бидэнд боловсролтой улс хэрэгтэй гэж Будягин хэлэв.

–Би ойлгож байна. Иван Григорьевич хэмээн Шарок дуртайяа ам нийлж – гэхдээ надаас хамаарахгүй шүү дээ. Шүүх, прокурорын байгууллагууд, гэтэл нөгөө ах маань... гэв.

–Эгертэд оч, түүн дээр очоорой, би утасдчихна. Тэгэхлээр хуулийн зөвлөх болох гэж байгаа юм шив дээ?

Яг хуулийн зөвлөх гэж хэлсэн нь зүрх маажчих шиг болох нь тэр.

Гэлээ ч зорьсондоо хүрлээ. Гагцхүү үр дүн нь чухал шүү дээ. Юмыг чинь ингэж хийдэг байна! Зарим хүнд хэцүү, зарим хүнд бүх юм амархан. Хуучин мөнгөтэй хүнд юм амархан байсан, одоо эрх дархтай хүнд амар болжээ.

Дээд сургууль, исгэлэн байцаа ханхалсан гуанз, дургүй хүрэм субботник, залхам хурал, байнгын сургаал номлол, буруу юм хэлчих айдас энэ бүхнээс ингээд салах нь тэр. Тэрээр үйлдвэрчний хорооноос өмдний ширүүн даавууны бичиг авах гэж царай алдаж байгаа оюутнуудаас ялгарахгүйн тулд сургууль дээрээ нэг ч удаа шинэ костюмтайгаа ирсэнгүй.

Тэд нар хуралдаж, баахан юм ярих нь мэдээж. Юра удирдлагуудын үг сонсдоггүй хүйтэн байдал, тэдний хортой царайг төсөөлнө. Шарок, зайлж зугтаж байх шив... Харин мань хүн тэдний өмнө тайван инээмсэглээд зогсож байх болно. Чухамдаа юу болсон юм бэ? Юунаас болж шуугихдаа хүрэв? Хүн өөрийг нь өсгөж бойжуулсан хамт олондоо л буцаж очих гэж байна. Хуучин тэнд долоон зуун ажилчин байсан, одоо таван мянга. Таван жилийн ууган үйлдвэр! Тэнд ажиллана гэдэг бол залуу мэргэжилтэнд нэр төрийн хэрэг. Тийшээ томилуулах гэж мань эр өөрөө хөөцөлдсөн үү? Яагаад өөрөө байх билээ? Ерөөсөө л үйлдвэрээсээ салаагүй явсан юм чинь. Тэгээд дээд сургуулиа төгсөөд буцаж ирэх хүсэл байна уу гэж асуухаар нь “хүсэл байна” гэж хариулсан хэрэг. Юу гэж хариулах ёстой байсан юм бэ? Тэрээр хувь заяаг нь, зөвлөлтийн энгийн нэг хүний заяаг ийнхүү анхаарч байгаад бахархаж байна.

Тэдэнд ингээд ивхийтэл нь хэлээд өгнө. Тэгэхэд тэд нар сүүлээ моосгонуулахгүй хаачих вэ. Тэр ч байтугай мөр алгадаж “За Шарок минь, ажиллаад өг, тэгэлгүй яахав!” гэх вий.

Тэрээр тэнд сургуулийн тэд нараас, энд Зөвлөлүүдийн тавдугаар байшингийнхаас илүү хүчтэй, давуу юмтайгаа мэдрэв. Энэ эрх дархт сэхээтнүүд гагцхүү түүнд өршөөл ивээл үзүүлдэг билээ. Хэрвээ Саша Панкратов Будягинаас тийм юм гуйсан бол Будягин түүнд намын илгээсэн газар л очиж ажиллах ёстой! гээд хавьтуулахгүй байсан даа. Хүндэлдэггүй хүндээ юухны ч өөдөс хаяж өгч болно. одоо энэ зоогийн цэлгэр өрөөнд сууж байгаа хүүхдүүд, өөрийнх нь сургуулийн найз нар мань хүнийг хэзээ ч хүндэтгэж байгаагүй. Мөн одоо ч гэсэн Иван Григорьевичээс тусламж хайж байна гэж ад үзэж байгаа. Юу л хүссэнээ бодож байг. Мань хүн Будягинаас зөвлөгөө авах гэж орсон ч юм билүү. Ахмад нөхрийнх нь хувьд. Чухам тийм л дээ, ахмад чинь яах гэж орсныг асуухгүй л дээ.

–Мэнд үү! гэж Шарок мэндлэв.

–Мэнд ээ! гэж Максим Костин нийтийн өмнөөс хариу мэндчилэв.

Цэрэг цамцаа толийтол индүүдэж савхин гутлаа гялалзтал тосолж халиун үсээ нямбайлан самнасан ханхар цээжтэй, улаан хацартай Максим бүтэн өдрийн чөлөөтэй залуухан сонсогчийн ёсоор малилзаж байна.

Нина Ивановна түүнтэй зэрэгцэж суугаад дутуу сугалсан шаахайгаа өсгийгөөрөө нидэрч харагдана. “Тэнэг толгой, нэг номероор томыг авчихдаг ч болоосой” гэж Шарок бодов. Нинка хэзээнээсээ олигтой хувцаслаж сураагүй, найр наадамд ч оч, нар салхинд ч яв, нэг цамцнаас салдаггүй билээ. Бас үсээ эвлүүлж чадахгүй, гэзгээ арагш нь самнахын оронд адуун духаа үсээрээ дарж хаах хэрэгтэй шүү дээ.

Шарок Вадим Марасевичийн мөр лүү нөхөрсгөөр алгадав. Москвагийн нэртэй нэг эмчийн эрх хүү, хоосон чалчихаас өөр хал балгүй энэ бандитай Юра хэвийн харьцана. Жижигхэн гүйлгэнэсэн нүдтэй, шилүүснийх лүгээ адил богинохон сахлаг хөмсөгтэй, паравгар уруултай, тарган шалхгар Вадим олбогт сандал дээр ялхайтал хэвтчихээд Уэллсийн тухай ярина.

Жаалхан Владлен Будягин урт хүрэн оймстой хөлөө бохирч суугаад дэвтрээ ширээгээр нэг тараачихсан хичээлээ хийж байна. Лена дүүгийнхээ муруйлган бичиж буй үзэгтэй гарыг хайнгахан дагуулан харж Юра руу инээмсэглэн толгой дохиж, суу гэв.

Ингээд тэдний бүлгийнхэн гүйцэх нь тэр. Ганцхан Саша Панкратов л алга.

–Уэллс дайн, тахал, АНУ-ын задрал болно, тэгээд засгийн эрхийг эрдэмтэд, нисэгч нар гартаа авна гэж зөгнөж байна хэмээн Вадим өгүүлэв.

–Хүн төрөлхтний түүх бол зөгнөлт роман биш, засгийн эрхийг аль нэг анги авдаг юм гэж Нина зөрөв.

–Тэр ч маргаангүй хэмээн Вадим дуулгавартай зөвшөөрснөө – Гэхдээ түүний ургуулан бодож байгаа нь сонин байна. Эрдэмтэд, нисэгч нар чинь ирээдүй эрх дархын хөшүүрэг, эд бол

орон зайг эрхэндээ оруулсан техникийн үзэлтнүүд гэхэд Максим,

–Найз нар минь, Герман зэвсэглэх нь ээ, бүгд зэвсэглэж байна гэв.

–Гитлер удаан тогтохгүй, найман сая хүн социал демократуудын төлөө санал өгсөн, коммунистуудын төлөө - таван сая өгсөн гэж Нина зөрөхөд Юра ярианд оролцож,

–Тэгвэл Тельманыг нуучихаж чадаагүй шүү дээ гэж хэлсэн нь ганц хүнийг хамгаалж чадаагүй таван сая бол юу ч биш гэсэн утгатай байжээ.

Гэвч түүний хэлсэн үгнээс нууц санаа хайх бодол хэний ч толгойд орж ирсэнгүй. Өөрснөө ямар ч эргэлзээгүй итгэдэг болохоор нөхрийнхөө итгэлд эргэлзэх юм даан ч байсангүй. Тэд нар хоорондоо маргаж хэрэлдэж болох боловч амьдралынх нь учир утгыг тодорхойлдог юмны тухайд цөм гуйвалтгүй итгэлтэй билээ. Ангийнх нь үзэл суртал марксизм, тэмцлийнх нь эцсийн зорилго дэлхийн хувьсгал, Зөвлөлт улс болон олон улсын пролетарийн ган бат цайз.

–Нууц ажиллагаа явуулах арга барилаас төсөөрцгөөчихөж л дээ гэж Максим хэлэхэд Вадим Марасевич тосон авч,

–Димитров тэр улсыг бут шиг сэгсчиж байна, ёстой нүдний хужир, энэ зуунд давтагдахгүй шүүхийн хурал! гэв.

Тэрээр Димитровыг шүүх хурлын тухай, дайн гарах боломжийн тухай, өөрөөр хэлбэл дайны өөрт нь ойлгомжтой, бусдад ойлгомжгүй шинж сэжгийн тухай яриа үүсгэв. Гэвч энд Вадимыг сайн мэдэх учир түүнд дураараа цуурах бололцоо өгсөнгүй. Дахиад алан хядалцах хэрэг үү? Арван сая хүний амь насыг бүрэлгэсэн дэлхийн дайныг хүн төрөлхтөн мартаагүй байгаа. Зөвлөлт Холбоот Улс руу довтлох уу? Дэлхийн ажилчин анги тэргүүлнэ гэж үү дээ? Түүнээс гадна Орос гэдэг чинь хуучинтайгаа огт адилгүй. Магнитка, Кузнецк ширэм гаргаж байна. Сталинград, Челябинск, Харьковт тракторынх, Горький, Москвад автомашиных, мөн “Фрезер”, “Калибр”, “Шарикоподшипник” гээд үйлдвэр завод ажиллаад эхэллээ, зөвлөлтийн анхны том цувах машинууд баригдлаа.

Тэдний сэтгэл зүрх бахархлаар бялхана. Өөрсдийнх нь эх орон, нөгөө дэлхийн пролетариатын өмнө барих гол хүч, нөмрөн айсуу дэлхийн хувьсгалын өмөг түшиг чинь энэ дээ. Ямар ч юман дээр өөрснийгөө гаргуунд нь орхиж, тасалбараар аж төрж байгаа нь үнэн, гэхдээ шинэ ертөнцийг барьж байгуулж байна. Гэдэс өлөн хүмүүст торгсины гайхуулам бараа сэлттэй цонхны үзэсгэлэн харшгүй муухай зүйл. Гэхдээ дэлгүүр өгсөн тэр алтаар ирээдүйн элбэг баян амьдралын баталгаа болох үйлдвэр заводыг байгуулна.

Тэд дандаа ингэж ярьдаг билээ. Эндхийн бүх юм ч яг хэзээний янзаараа. Хуу зүлгэсэн шал, намхан унжуулсан бүрхүүлтэй чийдэнгийн дор урт ширээ, ширээн дээр бүржмэл чихэр – энэ бүхэн бол амьдралаа зохицуулсан түшмэл айлын тав тух билээ. Ашхен Степановна цай аягалахдаа “Максим, чамд нимбэгтэй хийх үү?” гэж асуух бөгөөд тэгэх болгонд “Максим” гэдэг энэ орос нэрийг армян хүүхэн зориуд хачин хэлж байх шиг Шарокт бодогдоно.

Тэглээ ч гэсэн? Юм бүхэнд хүрэх зам нээлттэй байгаа энэ залуус чухам юунд хүрэв? Нина

багш. Лена техникийн номын сангийн англи хэлний орчуулагч. Максим явган цэргийн дунд сургууль төгсөж байгаа, армийн хударганд орно. Тэд цөм гэнэн цайлган сэтгэлтэй, гэтэл чухамдаа тэдний арчаагүй дутагдал тэр билээ. Юрий Шарокийн толгойд ийм л юм бодогджээ. Гэхдээ ингэж асуув.

–Хүүхдүүд ээ, Саша хаачаа вэ?

–Ирэхгүй гэж Максим хариулав.

Бусдын мэдэх ёсгүй юмыг мэдэж байдаг комсомолын идэвхтнүүдийн хямсгар занд Шарок дургүй, тэгээд ч саяын товчхон хариулт ч тиймэрхүү аястай санагдав.

–Ямар нэг юм болоо юу?

–Сашад эвгүй явдал тохиолдож энэ талаар аав Глинскаяд утасдсан гэж Лена хэлэв.

Сөхөрч цөхөрдөггүй Саша! Ёстой хачин хэрэг! Юра Шарокийн сэтгэл цэлсхийгээд явчихав. Шарокийг комсомолд элсүүлж байхад Саша товчхон “итгэхгүй байна” гэж хэлээд санал хураахад түдгэлзэж байсан билээ. Үйлдвэрт ороход Шарокийг зорогчийн дагалдангаар өгсөн, гэтэл Саша вагоны ачаа яаралтай буулгах ажилд саналаараа очоод тэндээ бүтэн жил зоогдчихсон, тэр нь уг ухаандаа улс оронд ачигч нар хэрэгтэй байна гэдгийг харуулж байгаа хэрэг. Түүхийн институтэд орох гэж байснаа больчихоод техникийн институтэд орчихсон. Улс оронд инженерүүд хэрэгтэйг ойлгож байгаа нь тэр. Яг л Будягины өрөөсөн дугуй, цаадах нь түүнд сүйд болдог нь дэмий хэрэг биш. Гэхдээ чухам юу болоо юм бол? Шал дэмий юм байсан бол Будягин оролцохгүй л байх ёстой доо.

–Манай сургуулийн нэг залуу хурал дээр “Эмэгтэй хүн гэж юу вэ? Сандлын хадаас...” гээд хэлээд тавьчихсан гэж Юра өгүүлэв.

–Мендель Маранцаас олоод уншчихаж дээ гэж Вадим Марасевич өчив.

–Гэтэл тэр нь Мартын наймны баярын хурал байсан юм. Түүнийг сургууль, комсомол, үйлдвэрчний эвлэлээс хөөчихсэн...

–Байраа олоогүй үг хэлжээ гэж Нина Ивановаг хэлэхэд Максим,

–Бүгдийг нь хөөгөөд байвал хэн үлдэх юм бэ? гэж хөмсөг зангидлаа.

–Сургуулиас хасна гэдэг ердийн дүрэм шиг болчих юм бол ерөөсөө хасах биш нэмэх болно доо гэж Вадим цэцэрхэв.

Лена Будягина хилийн чанадад, улс төрийн цагаачдын гэр бүлд төрсөн билээ. Хувьсгалын дараа дипломат эцгийнхээ хамт гадаадад аж төрж байгаад төрөлх хэлдээ маруухан хүн Орост эргэж иржээ. Тэрээр бусад нөхдөөсөө ялгарах дургүй, онцгой байдлыг нь илтгэх аливаа юмнаас санаа их зовно. Өөрт нь жинхэнэ ард түмнийх, жинхэнэ оросынх гэж санагдсан юм болгоныг тун эмзэг тусгаж авна.

Бусдын царай хардаггүй, биеэ голдоггүй, учир нь үл олдох жирийн нэгэн ажилчин хөвгүүн Юрка Шарок Ленагийн анхаарлыг дорхноо татжээ. Тэрээр түүнийг хүмүүжүүлэхэд нь Нина Ивановад тусалдаг байсан боловч энэ ажлыг гагцхүү нийгмийн сонирхлын үүднээс хийгээгүй гэдгийгээ ойлгоно. Бас Юра ч үүнийг ойлгоно. Гэвч хайр сэтгэлийн явдлыг жинхэнэ комсомолчдод байшгүй зүйл хэмээн сургуулийн хэмжээгээр ад үздэг билээ. Тэд хувьсгалын хүүхдүүд болохоор хувийн юмаар хөөцөлдөнө гэдэг бол нийгмийн хэргээс уравсан явдал болно гэж чин санаанаасаа итгэх бүлгээ.

Лена руу хааяа утасдах, кинонд буюу ресторанд урих, бүгдээрээ цугласан үед тэднийхээр орж гарахын жишээтэй харьцаа тэр хоёрын хооронд тогтож дунд сургуулиа төгссөний дараа ч Юра түүнд ойртох аль нэг эрс алхам хийлгүйгээр яг сайхан хуучин заншсан хэмжээндээ байдаг байлаа. Үүдний өрөөнд Ленаг тэвэрч авснаар Юра тэр хэмжээнээсээ хальж гарчээ. Санамсаргүй бүдүүлэгдүү хэрнээ Лена шиг хүнийг эзэмдэн авдаг эрс шийдэмгий байдлаар тэр заагийг давсан хэрэг.

Бүсгүй хэдэн өдөр түүний утасдахыг хүлээж цөхөөд хуучин бие биедээ утасддагийн адил зүгээр л юм шиг өөрөө утасдав. Бүсгүй үгээ жигд тайван, өргөлт дуудлагыг нь бодож, төгсгөлийг тов тодорхой дуудахыг эрмэлзэн яаралгүй ярив. Утсаар ярьж байгаа ч гэсэн түүний бишүүрхсэн инээвхийлэл мэдэгдээд байлаа. Гэтэл Юра утасдахыг нь хүлээж байсан ажээ.

—Би өөрөө чам руу утасдах гэж байсан юм. Надад Бүтээл клубт зургааны өдрийн хоёр билет байна. Нийтийн бүжигтэй. Хоёулаа явах уу?

—Явалгүй яхав.

Арван нэгдүгээр сарын зургаанд Юра Ленаг авах гэж тэднийхээр оров. Цаадах нь цэнхэр ногоон туяатай, ар хормой нь чирэгдсэн үдэшлэгийн урт хувцастай өөдөөс нь тослоо. Танихгүй сүрчигний үнэр ханхлан, гялгар хар үсэнд нь сувдан хэлхээ гялалзана. Лена үнэхээр өөр “ертөнцийн” бүсгүй, нүд алдам сайхан хүүхэн. Гагцхүү бишүүрхэнгүй мишээл нь хэвээр. Энэ мишээл нь би өөрийн чинь сэтгэлд нийцэж байна уу, үгүй юу, чухам өөрийнх нь төлөө л ингэж хувцасласныг ойлгож байна уу, үгүй юу гэж Юрагаас асуух мэт.

Лена зоогийн өрөөний хаалгыг нээж,

—Владик, арван цагт унтаарай гэв.

Владлен цонхны тавиур дээр нэг юм хийх зуур,

—Унтана аа гэв.

Юра бүсгүйд пальтог нь авч өгөхдөө,

—Танайхан хаачаа вэ? гэж асуув.

—Аав Краматорскт, ээж Рязаньд яваа.

–Баярт оролцох нь уу?

–Аав баяр болохоор дандаа үйлдвэр рүү явдаг юм, ээж бол лекц уншдаг.

Лена урт хормойгоо пальтон дотуураа шуух зуураа,

–Энэ нь л төвөгтэй эд байгаа юм гэж инээмсэглэн өгүүлэв.

Тэр хоёрын аз таарчээ. Хашаан дотроос нэг машин гарах гэж байв. Жолооч нь Ленагийн таньдаг хүн таарч тэднийг Мясницкая хүртэл дөхүүлж өгөв. Дээгүүр дарга нарын тэрэг барьдаг, нас ахимаг, зан ихэмсэг тэр жолооч Ленад ая тал засах хэрнээ Юраг харсан шинжгүй байжээ. Гэвч Юра энэ тухай бодсонгүй, Лена ганцаараа байгаа болохоор клубийн дараа тэднийхээр орж болох тухай л бодож явав. Зөөлөн суудал дээр зэрэгцэн суугаа бүсгүй ийм ойрхон байгаа нь сэтгэл хөдөлгөхийн хамт чухам өнөөдөр бүх юм болох вий гэхээс айх, санаа зовох хосолно.

Тэрээр хүүхнүүдтэй бишгүй уулзаж явсан боловч тэр нь шал өөр явдал байжээ. Хөрш айлын үйлчлэгч хүүхэн, тэдний хорооны нэг завхай охин, эцэгтэйгээ очдог байсан тосгоны бүсгүйчүүл энэ тэр бий. Тэд нар өөрсдийгөө бүрэн хариуцдаг болохоор ямар ч төвөг байгаагүй, гэтэл энэ удаад бол өөрөө бүх юмыг хариуцах ёстой болно, Будягинтай тогловол аюултай. Юрагаас өөр хүн бол гэрлэчихгүй юу, гэтэл мань эр дэндүү өндөрт хөөрчих гээд байх шиг санагдан нэг л айгаад болж өгдөггүй. Түүнээс гадна Лена яг өөрт нь хэрэгтэй тийм эхнэр байж чадах уу? Үзэл бодол тэс өөр, эвлэрч нөхөрлөшгүй тэдний гэр бүлийг өөрийнхөө гэрийнхэнтэй жишиж төсөөлж эс чадна. Азнах хэрэгтэй. Тэрээр өмгөөлөгч болж, биеэ даасан байдалд хүрэх найдвар тасраагүй хэвээр. Ленатай суучихвал өөрийгөө тэдний тэргэнд хүлээд хаячихсэн хэрэг болно.

Тэд нар Бүтээл клубийн дэргэд ирж зогсов. Юра машины хаалгыг яаж нээхээ мэдэхгүй хоёр янзын бариулыг ээлжлэн эргүүлж үзсэн боловч онгойсонгүй. Тэгмэгц Лена дээгүүр нь даван бөхийж хэрэгтэй бариулыг дараад ялдамхан инээмсэглэж,

–Энэ машины бариул их эвгүй шүү гэв.

Шарокийн будилсныг аргалах гэсэн оролдлого нь түүнийг ийм машинд хэзээ ч сууж үзээгүйг зориуд цохсон хэрэг болж мань эрийн дургүйг хүргэв. Гэвч тэрээр биеэ дахин барьж, жолооч руу ёозгүй хяламхийгээд Ленагийн араас Бүтээл клуб рүү орлоо. Тэрээр өөрийнхөө хүссэнийг хийж, өөртөө сайхан санагдсанаар л амьдрах хүн. Одоо бол Лена түүнд сайхан санагдаж байна. Дэргэд нь суугаа хүмүүс тэр хоёр руу хараа уралдуулж байгааг ажиглав. Тэрээр хүүхнүүдийн харцанд дассан ч гэсэн өнөөдрийнх бол хуучнаас шал өөр харц, энэ дотор байгаа нүд торох ганц хүүхний ивээлд өртсөн эр хүнийг сониучирхсан онцгой харц гэдгийг ойлгоно.

Русланова дуугаа дуулж, Зоценкогийн өгүүллэгүүдээс Хенкин уншлаа. Дараа нь бүжиг эхлэв. Лена дуулгавартай бүжиглэнэ. Бүжгийн тавцангаас салдаггүй охид шиг хөнгөхөн биш ч гэсэн болхидуухан байгаагаа өөрөө дооглон, Юра руу итгэмтгий зангаар налсхийн бүжиглэнэ.

Лена үсээ янзлахаар гарахад мань хүн баганын дэргэд үлдээд энд цугларсан хүмүүсийг ажиглав. Аж үйлдвэрийн удирдах хүмүүс, эрдэм шинжилгээний ажилтнууд, Ардын комиссарын газар ажиллаж, дарга нарын хажууд бөндөгнөн өндөр цалин, шан хүртэж хаалттай газруудаас бараажиж, ашиг хонжоотой албан томилолтоор явдаг, Москвагийн техникийн том сэхээтнүүд байх аж. Дээд сургууль төгссөний дараа удирдах байгууллагуудад шургаж амжсан азтангууд яаж түргэн ахиж дэвшдэг, харин үйлдвэрлэл рүү очсон нь ямаршуухан тэргэнд хөллүүлдгийг Юра сайн мэднэ.

Мань хүн үйлдвэр дээр юунд хүрэх билээ? Ажил тасалсан, ажлаас халсан тухай өчүүхэн хэрэг, бэржээнтэн бээлийний чанарын талаарх зарга заалхайг таслах гэж ардын шүүхүүдийн хооронд харайлгах болно. Ардын комиссарын газар, ерөнхий газар, трестийн хуулийн хэлтэс бол шал өөр хэрэг. Томоохон томоохон хэрэг шүүнэ. Холбоотын болон Бүгд Найрамдах Улсуудын дээд шүүх мэтийн дээгүүр албан газруудтай харьцана. Энэ бүхэн ирээдүйн өмгөөлөгчийнх нь албанд ч хэрэг болох юм билүү. Гэхдээ энэ бүхэн хожмын явдал. Одоо хамгийн гол нь нийтийн хуваариас л салах хэрэгтэй, тэгсэн цагт юм болгон хямдхан бүтнэ.

Цагийн зүү арван нэгийг зааж байлаа. Юра Ленагийн байрны жижүүр орцных нь үүдийг түгжчихээс өмнө буцаж очих санаатай байв. Тэгээд,

—Чи ядраагүй байна уу? гэж асуув.

—Жаахан байзная хэмээн Лена инээмсэглэн гуйв.

Тэднийг клубээс гарахад шөнийн нэг цаг хэдийн болжээ. Бүгчим танхимаас гарсан хүмүүсийг сайхан сэгхийтэл сэргээсэн сийрэгхэн бороо шивэрнэ, гудамжны дэнлүүний шилийг даган борооны ус савирна. Гадаа нэг ч хүн алга. Гагцхүү Лубянын талбай дахь Улс төрийн ерөнхий газрын цонхнууд гэрэлтэй харагдана.

Тэр хоёр явсаар Ленагийн байшин руу дөхөж ирэв.

—Орж жаахан суух уу?

Энэ үгийг Лена ямар ч төвөггүй хэлсэнд Юра ихэд гайхав.

Тэрээр бүсгүйн араас чимээгүй дагалаа. Нөгөө л өвгөн жижүүр хаалга онгойлгож өгөв. Гадны хүн ийм орой болсон хойно яагаад Будягиных руу явж байгааг ер асуусангүй. Тэгж сургасны хэрэг. Юунд ч гайхах ёсгүй.

Лена үүдний өрөөнийхөө гэрлийг асааж, зоогийн өрөөний хаалгыг жаахан онгойлгов.

—Унтаж байна... Аавын өрөөнд суузнаж бай, би хувцсаа солиодохъё.

Тэрээр аавынхаа ажлын өрөөний дээд гэрлийг асааж Юра руу дахин нэг инээмсэглэчихээд гарав.

Шарок давхарлаж тавьсан хэдэн номыг үзэв. Энд тэнд нь нарийхан цаас хавчуулсан Лениний нэг боть, төмөрлөгийн тухай ном, Алексей Толстойн “Нэгдүгээр Пётр” энэ тэр байх ажээ.

Албаны бичиг цаас, нууц товхимол, гагцхүү эд нарыг уншихыг зөвшөөрдөг хориотой ном, эд нарт заавал байдаг зэвсэг энэ тэр ер алга. Тэр зэвсэг нь арын халаасанд авч явахад эвтэйхэн браунинг гар буу гэдэгт Юра эргэлздэггүй юмсанж. Хориотой, халдашгүй аль нэг юмыг олж үзэх, тэдний засгийн нууцад шүргэх хүсэл сэтгэлийг нь эзэмдээд явчихав.

Лена хэзээ ч ороод ирж магадгүй, бушуулах хэрэгтэй. Тэрээр ширээний дунд нүдийг өөр рүүгээ татвал түгжээтэй байв. Хажуу талынх нь нүднүүдийг татаж үзсэнд мөн онгойсонгүй. Ленаг ижил дасал болсон цагаан цамц, хөх банзалтайгаа орж ирэхэд мань хүн олбогт сандалд дөнгөж сууж амжсан ажээ.

–Би кофе чаначих уу?

Бүсгүй дэргэдүүр нь хөдөлж, биеийг нь шүргэн, инээмсэглэхэх агаад кофе аягалах гэж ширээ рүү тонгойход нь мань эр түүний хөхийг олж харав. Тэрээр Ленатай шөнө ингэж хоёулхнаа хэзээ ч байгаагүй, ийм кофе, ийм ликёр дарс хэзээ ч ууж үзээгүй билээ.

–Дахиад уух уу?

–Үгүй ээ, болоо.

Тэрээр буйдан руу шилжиж суув.

–Жаахан сууцгаая...

Бүсгүй аягаа барьсан чигээрээ хажууд нь ирж суув. Мань хүн бүсгүйн гараас аягыг нь авч ширээн дээр тавив. Цаадах нь гайхшран инээмсэглээд өөдөөс нь харлаа. Тэгэхүйд Юра бүсгүйн айдас хурсан нүд рүү гудамжны харчуулын увайгүй янзаар эгцлэн харж, биеийг нь бие рүүгээ татлаа.

Саша арван нэгдүгээр сарын долоонд сургуулийнхаа жагсаалыг Тверийн гудамж, Гүржийн их гудамж хоёрын уулзвар дээр хүлээв.

Жагсаал зугуухан хөвөрнө. Эгнээнүүдийн дээгүүр туг далбаа намирч, уриа лоозон, хөрөг зураг багширна... Сталин... Сталин... Сталин... Хижээл эрчүүд гуулин хөгжмөө бодлогоширсон янзтай үлээж, жагсаалын дундаас ая хөг нийлээгүй дуу дуулах сонсогдон, хүмүүс хар зам дээр бүжиглэж товшин байна. Радиогоор яригчдын дуу хоолой, Мавзолейгээс баяр хүргэж хэлсэн үг, талбай дээгүүр өнгөрч байгаа жагсагчдын баярын уухай энэ тэр нийлсэн Улаан талбайн дуу шуугианыг чанга яригч түрэх мэт тархаана.

Тэдний сургуулийн жагсаал хоёр цагийн үед тэнд хүрч ирээд зогсчихов. Эгнээнүүд нь холилдчихлоо. Саша бөөн улсуудын дундуур чихэлдсээр ангийнхан дээрээ очив. Гэтэл цаадуул нь болгоомжилж хачирхсан янзтай ширтэцгээж байгааг тэр дорхноо анзаарлаа. Зовлон тохиолдсон хүнийг тэгж хардаг даа. Энэ ч нөгөө товчооны хурлынх биш ээ. Өөр л юм байж таарах нь.

Гэвч Сашад хэн ч юу ч хэлсэнгүй, мань хүн ч юу ч асуусангүй. гагцхүү түүний найз Руночкин нэг юм хэлэх гээд байх шиг байвч барьж яваа лоозонгоосоо хөндийрч чаддаггүй.

–Жагсаарай! Жагсаарай! гэж жагсаалын ахлагч нар хашгирлаа.

Эгнээнүүд тооцоотой байсан тул Саша жагсаалын адагт очиж өөр оюутнуудтай нийлэв. Тэндээс факультетнийнх нь далбаа, Руночкин, өөр нэг залуу хоёр барьсан хоёр иштэй лоозон илхэн харагдана. Лоозон салхинд татагдан гэдэсхийснээ даавуу нь жиширч нэгэнтээ мурийгаад буцаж тэгшрэв. Жагсаал хөдөллөө.

Тэгснээ Триумфийн талбай хүрэлгүй дахиад зогсов. Саша ангийнхан руугаа дөхтөл өөдөөс нь Руночкин ирэв.

–Ханын сонинг хураагаад авчихсан.

Руночкин атигар татанхайн гадна нүд нь бас сөлөр хардаг учир юм ярихдаа нүүр буруулж газар шагайна.

Ханын сонинг авчихжээ! Яагаад тэр вэ? Ийм явдал хэзээ ч болж байгаагүй.

–Хэн аваа вэ?

–Баулин. Шоглол шүлгээс болж авсан. Гавшгайчдыг гутаасан гээд.

Редактор нь Руночкин юмсанж. Гэхдээ шоглол шүлэг бичихийг Саша санал болгосон төдийгүй ангийн ахлагч Ковалёвын тухай “Махруу ажил хөдөлмөр маяг боллоо, мань хүн гэтэл тэс өөр байлаа, уртын аянд яваа мэт тэмдэглэл юугаа гээчихнэ, уншаагүй байсан хэрнээ бүхнийг бас мэднэ” гэж өөрөө зохиосон. Бусад гурван шоглолыг Роза Полужан

бичжээ. Борька Нестеровт: “Гахайн махан нухаш, ганц орц цагаан будаа бол Борисын шарилд босгох боломжийн дээд хөшөө”, Петька Пузановыг - нойрны ноён, Приходькод жолоодох дасгалыг зувчуулж, зовлонтой удаан унадаг гэж бичсэн аж. Гойдын юм алга, тэр байтуйгай инээдэмтэй ч юм алга, гэхдээ гэм хоргүй зүйл. Гэнэт “Гавшгайчдыг гутаасан” хэрэг гэнэ!

–Яаж гутаагаа вэ?

Руночкин толгойгоо гилжийлгээд,

–Шоглол шүлгээр. Яагаад зөвхөн гавшгайчдын гэрэл зургийг тавьсан, тэгээд шоглолыг хамтатгасан юм гэж би хэллээ. Гэтэл яагаад тэргүүн байхгүй байна? гэдэг байгаа даа.

Тэргүүн бичихгүй байхыг Саша бас санал болгосон.

Бусад сонинд гарах юмыг давгахын хэрэг юу билээ?! Байшингийн хонгилд хий хадаатай байхгүй, үнэхээр баярт зориулсан, хүн уншихаар хөгжилтэй дугаар гаргах хэрэгтэй. Цаадуул нь тэгэхэд санал нийлжээ. Гагцхүү хашир Роза Полужан л Саша руу жогтой харж,

–Тэргүүн бичээд гарын үсгээ тавьсан нь дээр гэжээ.

–Азизянаас айгаа юу?

Мань хүн Розад тэгж хариулсан билээ. Гэтэл ийм хэрэг явдал манддаг байна. Азизянтай холбогдсон явдал нэг тийш болоогүй сунжирсаар байхад бас нэг хэрэг үүслээ. За яахав, хамгаалж үзэлцэнэ дээ!

Страстная талбайд жагсаал бас л зогслоо. Эндээс цааш сааталгүй явчих учраас ахлагч нар жагсаалд хөндлөнгийн хүн байгаа эсэхийг нягтлан шалгаж, Улаан талбай хүртэл үлдсэн хэсгийг зогсож барилгүй түргэн явж өнгөрөхийн тулд жагсаалаа нягтруулж бэлтгэв.

Баулин, Лозгачёв хоёр нөгөө хэсэг рүү ирэв. Лозгачёвын ханцуйд сургуулийн жагсаалын даргын улаан даавуу уяатай аж.

–Панкратов, жагсаалд ирэх хэрэггүй гэж үзэж байна уу? хэмээн Баулин Саша руу ширүүн харлаа.

Энэ бол Баулины буруу. Хотод байдаг оюутнууд хэзээнээсээ нааш жагсаалыг амдан нийлдэг билээ. Түүнээс гадна хэдэн мянган оюутнаас хэн нь сургууль дээр очсон, хэн нь хожим нийлснийг Баулин мэдэх боломжгүй. Гэтэл Сашаг мэдчихсэн, лавлачихсан хүрч ирээд энэ явдлыг нь нийтийн өмнө цохож байна. Энэ олон хүний нүүрэн дээр Саша түүнийг эсэргүүцэж чадахгүй гэж Баулин бардам байгаа нь үнэхээр доромжилсон шударга биш хэрэг.

Яагаад эсэргүүцэж чадахгүй байх билээ?

–Би жагсаалд байж байна, та намайг харж байх шиг санагдах юм. Энэ бол хий үзэгдэл биш хэмээн Саша Арбатын сэхээтний багачуул зодолдохынхоо өмнө хиймэл боловсон зангаар өдөлцдөг маягаар хариулав.

Баулин,

–Хэрээ мэдэж гоодроорой гэхээс өөр юу ч хэлсэнгүй.

Тэгээд Сашагийн хариу өчихийг хүлээлгүй цаашаа яваад өгөв.

Жагсаал Түүхийн музейн хоёр талаар хоёр урсгал болон Улаан талбай руу хөврөн орж, хурдаа нэмсээр талбайд хүрмэгц эгнэсэн улаан цэргүүдийн хоорондуур хагаран бараг гүйх шахам алхална.

Сашагийн жагсаал Мавзолейн талаар гарч таарав. Индэр дээр ганган өмсгөлтэй цэргийн атташегаас авахуулаад олон хүн байвч тэдний зүг харах хүн байхгүй, бүх хүний харц гагцхүү Мавзолей руу тэмүүлэн, Сталин энд байна уу, үгүй юу, Сталиныг л олж харах юмсан гэх цорын ганцхан бодолд автжээ.

Тэгтэл ч түүнийг олж харжээ. Хар сахалтай нүүр нь тоо томшгүй олон зураг, баримлаас биелээд ирсэн гэлтэй. Тэрээр саравчтай малгайгаа урагш дарж өмсөөд хөдөлгөөнгүй зогсох ажээ.

Уухайн дууны хүч нэмэгдсээр, Сталин! Сталин! Саша бусдын адил түүнээс хараа эс салган мөн л Сталин! Сталин! гэж хашгирч явлаа. Хүмүүс индрийн урдуур өнгөрсөн хойноо ч эргэж харсаар явахад улаан цэргүүд тэднийг бүү саат! хэмээн яаруулна. Алхаад! Алхаад!

Василий Бланженный дуганы тэнд жагсаал эвдрэн холилдож, замбараагүй бөөн улсын урсгал Москва голын тийш уруудаж, гүүр өөд өгсөж, голын эргийн засмалыг бялхан дүүрнэ. Бүрээ, бөмбөр, туг далбаа, плакат, уриа лоозонгоо ачааны машинд ачицгаана. Ядарч өлссөн хүмүүс цөм гэр орондоо очихын түүс болж, Чулуун гүүр, Пречистенскийн хаалга руу, трамвайд суухаар яарна.

Энэ минутад талбай дээр уухай дээд цэгтээ хүрч аянгын нүргээн мэт голын эргээр нүргэлэн цуурайтсан нь Сталин жагсагчдыг мэндчилэн гараа өргөсөн хэрэг болой.

Баярын дараа намын байгууллагын товчооны өргөтгөсөн хурлыг яаралтай хийхээр зарлажээ. Хурлын бага танхимд цугларцгаалаа. Лозгачёв индэр дээр зогсоод цаасаа янзалж байна. Тэрээр,

–Манай факультетэд намын эсрэг хоёр хэрэг өдүүллээ. Нэгдэх нь тоо бүртгэлийн шинжлэх ухааны марксизмын эсрэг Панкратовын дайралт, хоёр дахь нь мөн тэрхүү Панкратовын гаргасан ханын сонин, Комсомолын гишүүн Руночкин, Полужан, Ковалёв, Позднякова нар Панкратовын хамсаатан болжээ. Ангийн коммунистууд, комсомолчид тэдэнд няцаалт өгөөгүй байна. Энэ бол улс төрийн сонор сэрэмж мохсоныг гэрчилж байна гэв.

Ханын сонины баярын дугаарт Октябрийн арван зургаан жилийн ойн тухай тэргүүн өгүүлэл байхгүй, нөхөр Сталины нэрийг нэг ч удаа дурдаагүй, гавшгайчдын зургийн дор хорон муухайгаар гүтгэсэн шүлгэрхүү тайлбар хийсэн. Жишээлбэл тэр тайлбаруудаас Панкратовын өөрийн нь бичсэн нэг нь ингэж байна: “Махруу ажил хөдөлмөр маяг боллоо, мань хүн гэтэл

тэс өөр байлаа, уртын аянд яваа мэт тэмдэглэл юугаа гээчихнэ, уншаагүй байсан хэрнээ бүхнийг бас мэднэ”. “Хөдөлмөр маяг боллоо” гэдэг чинь юу гэсэн үг вэ?... гээд Лозгачёв танхимыг ширүүн харцаар эргэлдүүлэн харснаа – Одоо манайд хөдөлмөр “маяг” гэж үү? Манайд хүмүүсийн хөдөлмөрөөр социализмын суурийг байгуулж байна. Манайд хөдөлмөр бол нэр төрийн хэрэг. Гэтэл Панкратовын хувьд энэ бол зөвхөн ээлжит “маяг” төдий зүйл гэнэ. Манай хүмүүсийг гүтгэн гүжирдэх гэсэн хорон санаатан л гагцхүү ингэж бичиж чадна. Гэтэл өнгөрсөн товчооны хурал дээр зарим хүн Панкратовыг цагаатгах гэж оролдон, Азизяны лекцийг дайрч доромжилсон, Криворучког өмгөөлсөн энэ тэрийг санамсаргүй зүйл гэж мэтгэж байсан.

–“Зарим хүн” гэдэг чинь хэн бэ? гэж Баулин хэний тухай ярьж байгааг бусдын адил мэдэж байсан хэрнээ зориуд асуув.

–Би факультетийн декан Янсоныг хэлж байна. Тэр ч хариуцлагаас мултрах ёсгүй гэж санаж байна.

–Мултрахгүй гэж Баулин амлав.

–Нөхөр Янсон факультет дотроо амарлингуй, тоомжиргүй уур амьсгал бий болгож, тэгснээрээ Панкратовг улс төрийн хорлон сүйтгэх ажил явуулах боломж олгожээ хэмээн Лозгачёв лавшруулав.

Хоосон сүржигнэгч, бялдуучаараа сургуулийн хэмжээнд зард гарсан дөрөвдүгээр курсийн оюутан Карев гэгч царайлаг залуу,

–Гутамшиг! гэж хашгирав.

–Сургуулийн намын байгууллагын товчоо Панкратовын явууллагыг дор нь тас цохиж, ханын сониныг хурааж авсан. Энэ бол намын байгууллага бүхэлдээ эрүүл байгааг гэрчилж байна. Бидний хайр найргүй хатуу шийдвэр үүнийг дахин нотлох болно гэж Лозгачёв үгээ дуусгав.

Тэрээр цааснуудаа эмхэлж аваад индрээс буулаа.

–Редактор энд байна уу? гэж Баулин асуув.

Хүмүүс Руночкин руу харж суудал дээрээ хөдөлцгөөлөө. Сөлөр нүдтэй атигар Руночкин индэр лүү гарав.

–Руночкин, та яагаад ийм байдалд хүрснээ ярь даа гэж Баулин нөгөө л хорлонтой хээгүй байдлаараа өгүүлэв.

–Сургуулийн хэвлэмэл сонины тэргүүнийг давган хуулах хэрэггүй юм гэж бид бодсон юм.

–Хэвлэмэл сонин энд ямар хамаа байна? Та нарыг ханын сонин гаргаж байхад хэвлэмэл сонин гарч амжаагүй байсан хэмээн Баулин хөмсөг зангидав.

–Гэхдээ дараа нь гарсан шүү дээ.

–Тэгээд та нар тэнд ямар тэргүүн байхыг мэдэж байсан хэрэг үү?

–Мэдэлгүй яахав

Хүмүүс инээлдэв.

–Та битгий томоогүй хүн болох гээд бай, тэргүүн хэн бичүүлээгүй вэ? Панкратов уу? гэж Баулин уурлав.

–Санахгүй байна.

–Санахгүй байна гэнээ... таны гайхаш төрөөгүй юу?

Руночкин дал мөрөө хавчихаас хэтэрсэнгүй.

–Тэгвэл шоглол шүлэг бичих тухай Панкратовын санал хачин санагдаагүй юу?

–Бид хуучин ч бас бичдэг байсан юм.

–Та алдаагаа ойлгож байна уу?

–Нөхөр Лозгачёвын ярьж байгаагаар авч үзвэл ойлгож байна.

–Та өөрөө юу гэж үзэж байна?

Руночкин дуугарсангүй.

–Юу ч мэдэхгүй хүний дүр гаргаж байна! гэж Карев дахиад хашгирав.

Баулин цаасаа харлаа.

–Позднякова байна уу?

Тэрүүхэндээ хөөрхөн Позднякова инээмсэглэсээр индэр лүү очив.

–Би юу хэлэх вэ? Саша Панкратов тэргүүн бичихгүй гэж шийдсэн, тэр комсомолын дарга юм чинь бид түүний үгийг дагах ёстой шүү дээ.

–Хэрвээ тэр таныг таван давхраас харай гэж тушаасан бол яах вэ?

–Би харайж чаддаггүй, би уг нь ингэж бодсон...

Баулин түүний үгийг тасдан,

–Та юу ч бодоогүй байна. Эсвэл эрдэм номын гавшгайчуудыг ингэж доромжлох нь танд сайхан байсан хэрэг үү? гэв.

–Үгүй.

–Яагаад эсэргүүцсэнгүй вэ?

–Тэд нар миний үгэнд орохгүй байх байсан.

–Тэгвэл намын хороонд хэлэхгүй яасан юм бэ?

–Би... би.. гээд Позднякова нусныхаа алчуурыг нүд рүүгээ аваачлаа.

–За мэдлээ, суу! гээд Баулин дахин цаас руугаа харж – Полужан! гэв.

–Эд нараар яриулж яах юм бэ, Панкратов л хариулбал таарна! гэж танхим дундаас нэг хүн хашгирав.

–Панкратовын ээлж аяндаа ирнэ. Полужан, яриарай!

–Энэ бүх болсон явдлыг би том алдаа гэж үзэж байна хэмээн Роза эхэллээ.

–Олон янзын алдаа байдаг шүү!

–Би үүнийг улс төрийн алдаа гэж үзэж байна.

–Хэл амнаасаа чангаалгаад байхгүй шууд л тэгээд хэлэх хэрэгтэй шүү дээ.

–Би үүнийг улс төрийн бүдүүлэг алдаа гэж үзэж байна. Би тэргүүн өгүүлэл бичихийг санал болгож байсныг анхааралдаа авахыг зориуд хүсэлт болгоё.

–Санал гаргаж байсан гээд таныг зөвтгөж болно гэж үзэж байна уу? Та хаяагаа манаж биеэ зайлуулж байна, гэтэл ийм муухай юм ханан дээр өлгөөтэй байна гэхэд таны сэтгэл зовсонгүй юу? Та өөрөө шоглол шүлэг бичсэн үү?

–Тэгсэн

–Хэнд?

–Нестеров, Лузанов, Приходько гуравт.

–Нэг нь хоолны лүү, нөгөө нь нойрны тулам, гурав дахь нь луйварчин. Та ийм юмыг гавшгай үйлсийг алдаршуулж байна гэж үзэж байгаа юм биз дээ?

–Энэ бол миний алдаа хэмээн Роза шивэгнэв.

–Суу!... Ковалёв!

Царай нь цайчихсан Ковалёв индэр рүү гарав.

–Би дараах зүйлийг шударгаар хүлээх ёстой. Энэ хурал руу явж байхад энэ явдлын улс төрийн мөн чанар надад бүрэн тодорхойгүй байжээ. Хэдийгээр орон цагаа олоогүй мунхаг тоглоом гэдэг нь ойлгомжтой ч ямар ч атугай тоглоом л юм шиг санагдсан. Гэтэл бид бүгдээрээ

Панкратовын гар хөл болчихсоныг би одоо ойлголоо. Уг нь би тэргүүнтэй байлгана гэж зүтгэсэн нь үнэн. Гэвч шоглол шүлгийн тухайд би дуугүй өнгөрсөн юм. Миний тухай ч бас шоглол шүлэг бичигдсэн болохоор хэрвээ би эсэргүүцэх юм бол эд нар намайг өөрийгөө шүүмжлэлээс хаацайлж байна гэж бодно гэж санасан.

–Нэрэлхээ юү? хэмээн Баулин жишлэв.

–Тийм.

–Ковалёв шууд товчоонд ирж, юу болсныг бүгдийг шударгаар ярьсан гэж Лозгачёв өгүүлэв.

–Ханын сониныг хадахаас өмнө ирсэн бол дээр байхсан гэж Баулин зөрөв.

Байр зүйн багш Сиверский бослоо. Энэ хүнийг намын гишүүн гэж Сашагийн санаанд ёстой орсонгүй. Морин цэргийн хөх галифе өмдтэй, кавказ хийцийн урт цагаан цамцтай, цэргийн албан хаагчийн донжтой энэ дуу ховортой хүн Сашад хааны армийн хуучин офицер шиг санагдана.

–Ковалёв! Та өөртөө бичигдсэн шоглол шүлгийг эсэргүүцэхээс нэрэлхсэн үү?

-- Тийм.

-- Бусдад зориулсан шоглол шүлгийг яагаад эсэргүүцээгүй юм бэ?

–Хий сүржин асуулт байна! гэж Каревийн дуу хадлаа.

–Хэргийг будлиулж байна! гэж өөр нэг хүн хашгирав.

Баулин танхимд байгаа хүмүүсийг нийтэд нь гараараа дохиж заагаад,

-- Нөхөр Сиверский, хурлынхан таны асуултыг хэрхэн үнэлж байгааг сонсоо биз дээ? гэв.

–Би Ковалёв гэдэг энэ залууд амьдралаа ингэж эхлэх хэрэггүйсэн гэж л хэлэх гэсэн юм гэж Сиверский тайван өгүүлээд суучихав.

–Та хэлэлцэх үед ярьж болно шүү гэж Баулин хариулаад – Одоо гол зохион байгуулагчийг сонсоцгооё. Панкратов яриарай гэв.

Саша арын эгнээнд бусад факультетийн оюутнуудын дунд суугаад асуулт хариултыг чагнан, юу хэлэхээ эргэцүүлэн бодож байжээ. Түүнээс алдаагаа хүлээх, яаж гэмших, юугаар өөрийгөө зөвтгөхийг нь хүмүүс сонсох гэж байгаа. Тэрээр ийм хэрэг мандсанд харамсаж байгаа билүү? Харамсаж байгаа. Азизянтай ам муруйхгүй байж чадах байсан, ханын сониныг хуучин гаргадгаараа гаргаж бас чадах байсан. Хэрвээ тэгсэнсэн бол өөрийнх нь болоод нөхдийнх нь амьдралд тэнгэрээс унах мэт санамсаргүй, тун тоогүй орж ирсэн энэ хэрэг явдал огт байхгүйсэн дээ. Тэглээ ч гэсэн нөхдөө хамгаалж, хэлэх юмаа хэлж, тэсэж өнгөрүүлэх хэрэгтэй. Энд зөвхөн Баулин, Лозгачёв, Карев энэ тэр байгаа биш, энд Янсон, Сиверский болон өөрийнх нь нөхөд байгаа, тэд ойлгож дэмжинэ.

Танхимд нам гүм болов. Тамхи татах гэж гарсан хүмүүс эргэж ирлээ. Илүү сайн харахын тулд олон хүн суудлаасаа босов.

–Надад хүнд ял оногдуулж байна. Нөхөр Лозгачёв улс төрийн хорлон сүйтгэл, намын эсрэг хэрэг, хорон санаатан гэхчлэнгийн үг хэллэг хэрэглэлээ... хэмээн Саша эхлэхэд,

–Яг зүйтэй хэрэглэсэн! гэж Карев бололтой нэг хүн хүмүүсийн дундаас хашгирав. Гэвч Саша иймэрхүү өдүүлгийг тоохгүй гэж дотроо шийджээ.

Баулин харандаагаар ширээ тогшлов.

–Доцент Азизян лекц уншихдаа онолын хэсгээ практик ажилтай хослуулж чадаагүй учраас энэ хичээлийн чухал чухал зүйлтэй бидний танилцах бололцоог боогдуулсан хэмээн Саша үргэлжлүүлэв.

Азизян ухасхийн боссон боловч Баулин гар дохиж суулгав.

–Ханын сонины тухайд гэвэл юуны өмнө би комсомолын зохион байгуулагчийн хувьд энэ дугаарын хариуцлагыг бүрэн хүлээх ёстой.

–Яасан ариухан амьтан бэ! Жүжиглээч! гэж хүмүүсийн дундаас хашгирах сонсдов.

–Тэргүүн хэрэггүй гэж би л хэлсэн, шоглол шүлэгтэй гаргая гэж би санал гаргаж, өөрөө хүртэл нэрийг нь бичсэн юм чинь. Үүнийг манайхан чиглэл өгч байна гэж үзсэн байж болно.

–Чиглэл ий? Та хэнээс чиглэл авсан болж байна? гэж Баулин Сашаг эгц ширтэж асуув.

Саша эхлээд асуултыг ойлгосонгүй. Тэгээд цаад утгыг нь сая ойлгомгоц,

–Намайг доромжлох асуултаас бусад ямар ч юм асуусан таны эрх. Би одоохондоо хөөгдөөгүй байна гэж хариулав.

–Хөөхдөө л хөөнө, бүү санаа зов! гэж нэг хүн хашгирав. Энэ ч гарцаагүй Карев л даа.

–Цаашилбал манай хэвлэмэл сонин, факультетийн албан товхимолд гарах юмыг давтмааргүй санагдсан учраас тэргүүн бичээгүй юм. Тэнд илүү нарийн мэргэжлийн сэтгүүлчид байгаа шүү дээ...

–Шоглол шүлгээс үзэх юм бол чи чинь бүр яруу найрагч юм шив гэж Баулин дооглонгуй өгүүлэв.

–Цаас цоохорлогч! гэж хашгиралдах сонсдов.

–Тэргүүн бичих хэрэгтэй байж. Би алдаа гаргасан байна. Шоглол шүлгийн тухайд гэвэл буруутгахаар утгатай зүйл байхгүй л дээ. Гагцхүү тэдгээрийг гавшгайчдын зураг дор бичсэнд л хамаг буруу байна. Энэ л шал өөр утгатай болгочихож.

–Яах гэж бичсэн юм бэ?

–Залуучуудыг баяраар хөгжөөх гэж бодсон.

–Хөгжилтэй болжээ, яриа алга гэж Баулин өлгөж авав.

Бүгд инээлдэв.

–Харин намайг улс төрийн хорлон сүйтгэх явуулга хийсэн гэж яллах гэж байгааг би эрс няцааж байна гэж Саша хэлэв.

–Панкратов, та хэн нэг хүнээс туслалцаа гуйсан явдал бий юу? гэж Баулин асуув.

–Байхгүй.

Баулин Глинская руу харснаа Саша руу эргэж,

–Ардын комиссарын орлогч Будягинаас яасан бэ? гэж асуулаа.

–Яагаа ч үгүй

–Тэгвэл яагаад тэр чинь сургуулийн захиргаанд хүсэлт тавьсан юм бэ?

Саша Маркийн нэрийг хэлмээргүй байсан боловч өөр замгүй болов.

–Би энэ тухай манай нагац ах Рязановг ярьж байсан, бодвол тэр Будягинд хэлсэн бололтой.

–Бололтой... хэмээн Баулин доогтой давтаж өгүүлэхэд – Рязанов чинь Дорнодод байгаа шүү дээ гэв.

–Москвэд ирээд явсан юм.

–Рязанов Москвэд санамсаргүй ирж, та түүнд санамсаргүй ярьж, тэр нь Будягинд санамсаргүй хэлж, Будягин Глинскаяд санамсаргүй утасдаж... Панкратов аа, дэндүү олон санамсаргүй болж байгаа бус уу? Би тойруугаар арга зам хайсан юм гээд шуудхан хэлчихвэл илүү шударга болохсон доо?

–Үнэн хэрэгтээ ямар байсныг л би ярилаа.

–Аргацааж байна! Шударга бус байна! Чин сэтгэлээсээ ярихгүй байна!

Бас нэг хэдэн орилооч Каревтай хоолой нийлүүлж байгаа нь энэ.

–Танд өөр хэлэх юм алга уу?

–Би бүх юмаа хэлсэн.

–Суу.

Саша индрээс буув.

–Үг хэлэх хүн байна уу? гэж Баулин асуув.

–Янсоноор яриулъя! Янсон! Янсон яривал таарна!

Янсон уцаар царайлсаар индэр лүү гарав.

–Нөхөд өө, хэлэлцэж байгаа асуудал бол маш чухал юм.

–Чамтай чамгүй мэдэж байна гэж хашгиралдах сонсдов.

–Гэхдээ бодит үр дагаварыг нь хувь хүний юу бодож байснаас салгаж авч үзвэл зохино.

–Энэ чинь яг нэг зүйл

–Бүү номчирх!

–Үгүй, энэ нэг зүйл биш! Би хэлэх гэсэн санаагаа дуусгаж болохсон болов уу...

–Болохгүй! Одоо боль!

Сиверский дахиад босож ирлээ.

–Нөхөр Баулин, үймүүлээд байгаа улсыг болиулж өгөөч. Ийм байдалд ажиллах арга алга.

Баулин энэ хүсэлтийг сонсоогүй дүр гаргав.

–Панкратов улс төрөөс хөндий байр суурьтай, тэгэхлээр бэртэгчин байдалтай байжээ хэмээн Янсон улайран үргэлжлүүлэв.

–Зөөлдүүлж байна! Зөөлдүүлээ! гэж Карев хашгирав.

–Алив нөхөд өө, хүлээзнээч, намайг сонс л доо... гэж Янсон нүүрээ үрчийлгэв.

–Сонсох юм алга!

–Энэ явдлыг намын эсрэг явуулга, улс төрийн хорлон сүйтгэх ажил гэж нэрлэхийн тулд Панкратов санаатай хийсэн гэдгийг тогтоох ёстой, гагцхүү зориудын санаа байж байж...

–Битгий бултаад бай!

–Өөрийнхөө тухай, ямар үүрэгтэй байснаа ярь!

–За тэгэхлээр, Панкратов намын үйл хэрэгт хор хүргэхийг хүссэн үү? Зориуд ухамсартайгаар тэгэх гэсэн санаа байгаагүй гэж би бодож байна.

–Эвлэрэгч! Бүрхэгдүүлж байна!

–Нөхөр Янсон, болсон явдалд ямар үүрэгтэй байснаа ярихыг танаас хүсээд байна шүү дээ гэж Баулин хэлэв.

–Би ямар ч үүрэг гүйцэтгээгүй. Би сонин гаргаагүй, гаргах зөвшөөрөл өгөөгүй. Доцент Азизян надад биш, танд хүсэлт тавьсан.

–Тэгвэл та яагаад ханын сониныг аваагүй вэ? гэж Баулин асуув.

–Та эхлээд үзсэн юм байлгүй.

–Та яагаад хараагүй байдаг билээ? Танд илүү ойр биш билүү?

Янсон дал мөрөө хавчив.

–Хэрэв та ийм юмыг бодолцож байгаа бол...

–Болоо! Больё!

Янсон хэсэг зуур зогссоноо дал мөрөө дахин хавчаад суудал руугаа явлаа.

Баулин индэр рүү гаралгүй, тэргүүлэгчдийн ширээний араас ярив. Пиджакаа тайлж сандлын аравчнаас өлгөөд давуулж товчилдог захтай цамцтайгаа үлдлээ. Тэрээр инээмсэглэх битгий хэл мишилзэх ч үгүй ширүүн дориун үгээр буулгаж гарлаа.

–Панкратов зэмгүй өнгөрнө гэж тооцжээ. Дээгүүр хүмүүсийн ивээлээр болно гэж боджээ. Намын байгууллага тэдгээрийн мундаг нэрнээс хулчийна гэж итгэж байжээ. Гэвч намын байгууллагын хувьд намын үйл хэрэг, намын шугамыг цэвэр нандин байлгах явдал ямар ч мундаг нэр, ямар ч нэр төртэй хүнээс дээгүүр билээ...

Тэр алга ташихад зориулан түр чимээгүй боллоо. Хоёр гуравхан газар шад падхийх төдий дуулдахад Баулин өөртөө алга ташуулах боломж олгохгүй байгаа дүр үзүүлэн үгээ үргэлжлүүлэв.

–Комсомолын гишүүн Руночкин, Позднякова, Полужан, Ковалёв нарыг харахад ичмээр байна. Нөгөө хэдхэн хоногийн дараа инженер, зөвлөлтийн мэргэжилтнүүд болох гэж байгаа улс чинь энэ. Нөхөр Янсон улс төрийн хувьд ямар арчаагүй, ямар мохоо хүмүүсийг хүмүүжүүлсэн байна вэ. Эд нар ангийн дайсны гарт яагаад тийм амархан тоглоом болдгийн учир энэ. Бидний Янсоныг буруушааж байгаа юм бол чухам энэ. Нөхөр Янсон, та Панкратов мэтийхэнд аятай хөрс шороог бүрдүүлж өгчээ... Энд хүртэл та түүнийг хаацайлах гэж оролдож байна. Энэ чинь ч санаа зовоож байна шүү.

Би чамд хайртай, чи надад хайртай, ингэхлээр тэдэнд өөр юу ч хэрэггүй хэмээн Юра харилцаагаа нууц байлгахыг Ленагаас шаардана. Чухам энэ учраас мань эр түүний эцэг эх, танил тал болон гэр орноос нь зайлсхийж байгаа гэж ярина. Юрагийн аминч занг хөндөх вий гэж айгаад Лена бууж өгчээ.

Эцэг нь Юраг гэртээ охид дагуулж ирэхийг эс зөвшөөрнө. Гэтэл ардын комиссарын охин гэдэг чинь тоглоом биш шүү! Юрад ийм бүсгүй урьд нь байгаагүй. Эцэг эх нь Юра дээр нэг бүсгүй ирээд байх боллоо, за яахав, залуусын явдал, зан зангаа авбал сууцгаана л биз, эс тэгвэл сарницгаана л биз хэмээн Ленад нэг их сүйд болцгоогоогүй ажээ. Энэ нь ч чухамдаа эрин зуунтайгаа хөл нийлүүлсэн хэрэг. Харин гэрлэхдээ хүрдэг юм бол бүсгүй хадам эх эцгийгээ хүндлэх л ёстой болно. Хурим найраасаа өмнө өвөр түрийд нь орчихдог бүсгүйчүүлтэй хүн барагтай л бол гэрлэх биш дээ, тэгэхлээр хэдийгээр ардын комиссарын охин ч гэсэн Юрад талархах л ёстой.

Тийнхүү сүйд болохгүй байгааг нь Лена тэдний нэр төрөө хамгаалж буйгийн илрэл гэж санажээ. Юрагийн эцэг эх хоёр бүсгүйд бас л ер бишийн хүмүүс шиг санагдана. Эцэг нь томоотой сайхан мастер, эх нь сүсэг бишрэлтэй авгай, аж амьдрал нь хууччуулын янзтай, ер нь л жинхэнэ ардын хээ шаагүй амьдрал, шал өөр ертөнц.

Тэд нар заримдаа Владимирийн Цагаан далайн сувгаас бичсэн захидлын тухай ярилцна. “Эрхэм хүндэт аав”, “эрхэм хүндэт ээж”, “эрхэм хүндэт төрсөн дүү Юрий” гэхчлэнгийн угтэй, баларсан хувь заяагаа харамсан уйлсан шоронгийн гунигт шүлэгтэй, “цэнгүүн шувуухай шиг жиргэх” хүсэл мөрөөдөлтэй ял эдэлж буй эрүүгийн хэрэгтний захидал. Юра Ленагаас ичсэндээ дэмий л үрчийн байхад Лена эцгийнх нь дүнсгэр анхаарал, эхийнх нь гунигт санаашрал, намтар түүхийг нь ярвигтай болгосон энэ явдлыг Юрагийн тэвчиж байгаа тэсвэр энэ тэрд уяран суудаг ажээ.

Тэдний борог хоолноос эхлэн эцэг нь гарынхаа шохойг яаж арилгаж, хувцсандаа наалдсан утсыг яаж гүвж байгаа, хүнд ажлынхаа шан болгон, халуун бүл дотроо хоолоо идэхээр ажилчин хүний намбаар ширээ рүү яаж сууж байгаа хүртэл бүх юм бүсгүйн сэтгэлд сайхан санагдана. Бас гэрийн эзэн тэжээгч учраас эзэгтэй хамгийн түрүүнд хоолоо түүнд таваглаж, дараа нь эр хүн, ажлын хүн хэмээн Юрад хийж, түүний дараа зочиндоо буюу Ленад өөрт нь хийж өгөөд эзэгтэй хүн байнга гал тогоотой ноцолдон гэдэс алдана гэж байхгүй гэсэн шиг юухан үлдсэнийг нь өөртөө хийж авдаг заншил ч сайхан санагдана. Дор бүрдээ мөр мөрөө хөөгөөд хэдэн долоо хоноогоор ч хамаагүй хоорондоо уулздаггүй өөрийнх нь гэр бүлтэй огт адилгүй бат гагнагдсан нөхөрсөг гэр бүл.

Бүсгүй Скоморовскийг сонсох гэж “Метропольд”, Цфасманыг сонсох гэж “Гранд-отельд” Юратай хааяа очно. Лена ажил хийж цалин авдаг болохоор мөнгө зарах юман дээр адилхан гаргана, тэгэхгүй бол нөхөрсөг бус хэрэг гэж зүтгэж байгаад тийм эрхээ хамгаалж чаджээ. Юра их л нигүүлсэнгүй зан гаргаж байгаа мэт зөвшөөрсөн аж. Ийм сайхан хүүхэн өөрт нь зориулж мөнгөө гарлагадаж байгаа, рестораны зөөгч нар тэр хоёрт цөгцгөнөж байгаа энэ тэрд түүний бах ханана. Зэргэлдээх ширээнүүдийн ард ганган хүүхнүүд, сайхан хувцастай

харчуул сууж хөнгөн хөгжим эгшиглэн, “Метропольд” гэрэл унтрахад өнгө өнгийн гэрэлтүүлэг танхимын голд тойрон бүжиглэдэг усан оргилуурыг гийгүүлнэ. Юра Лена руу инээмсэглэн харж гарыг нь чанга чанга атган бүх хүн тэр хоёрыг анзааран буйд сэтгэл өег сууна.

Лена шөнө орой болсон хойно тэднийхээс явах бөгөөд цаадах нь зөвшөөрч гэмээ нь бүр явахгүй ч байхсан билээ. Гадаа хаалгыг шөнө түгждэг учир мань бүсгүй хонхдох хэрэг гарна. Нойрмог хашаачин гарч ирэх тоолондоо түүнийг сэжигтэй харах тул бүсгүй нэг рубль атгуулчихаад бушуухан гүйчихнэ. Бүсгүйн хөлийн чимээ шөнийн Арбатын явган замаар тодхон тожигноно. Гэрийхэн нь түүнийг бас оройтлоо гэх бөгөөд бүх юмны учрыг таамаглаж байвч юу ч асуухгүй. Эцэг нь Юрад дургүй, түүний тухай доогтой юм уу, эсвэл бүр үзэн ядсан янзтай юм ярина. Гэвч эцсийн бүлэгт энэ бол түүний хувийн хэрэг. Бүсгүй гэр орондоо дассан хүн, гэхдээ хэрэг болвол гэрээсээ яваад өгөхийг юман чинээ бодохгүй.

Арван хоёрдугаар сарын эхээр Юраг Шүүхийн ардын комиссарын газар дуудав. Боловсон хүчний хэлтсийн эзэнгүй олон ширээтэй том өрөөнд дунд хэрийн насны хавчиг цээжтэй, хонгордуу үстэй нэг хүүхэн түүнтэй уулзав. Тэрээр нэрээ Малькова гээд Юра руу харж, ширээний эсрэг талд байгаа сандал руу заав.

–Нөхөр Шарок, та сургуулиа төгсөх гэж байна, тэгэхлээр удахгүй ажилд хуваарилагдана. Тантай ойр дөт танилцах гэсэн юм. Өөрийнхөө тухай ярь даа.

Шүүх прокурорын байгууллагад орохгүйн тулд Юра уул нь Мальковад барагтайхан байдалтайгаар харагдвал зохих байсан юм. Гэтэл ямар ч хир буртаггүй, сэвгүй болж харагдах, нэр хорлож болзошгүй аливаа юмыг нуух талаар базаасан олон жилийн дасгал сургууль, биеэ хамгаалах зөн хар аяндаа хөтлөөд явчихжээ. Тийнхүү өөрийнхөө тухай байнга ярьдаг юмаа ярив. Оёдлын үйлдвэрийн ажилчны хүү, токарьчин хийж явсан, комсомолын гишүүн, арга хэмжээ авагдаж яваагүй. Бас төвөгтэй юм бий, ах маань хулгайн хэргээр ял эдэлж байгаа. Энэ төвөгтэй юмаа дурссан нь яриаг нь улам илэн далангүй болгож байх шиг өөрт нь санагджээ.

Малькова тамхиа татан анхааралтай чагнаж байснаа тамхиныхаа ишийг үнсний саванд нухаж унтраагаад,

–Та чинь комсомолын гишүүн байж ахыгаа яагаад алдчихсан юм бэ? гэв.

–Түүнийг шоронд ороход би арван зургаатай байсан.

–Хувьсгал хийхэд арван зургаан настнууд хороо хамаандалж байсан.

Малькова үүнийг өөрөө арван зургаан насандаа хороо хамаандалж явсан мэт хэлэв. Хамаандалж явсан ч юм билүү! Савхин цамцтай, тамхи зуучихсан, хариугүй хорчийж хатангирлаад, цэрэг л гэлтэй... тэгсэн ч ямар хамаа байна! Бүх хүн хамаандалж явах ёстой юм уу? Хороо яаж хүрхэв дээ! Гэтэл үйлдвэр рүү оруулах уу, эсвэл газрын мухар руу цөлөх үү гэдэг энэ шаргачингаас хамаарах гээд байдаг. Энэ жилийн бүх төгсөлтийг Баруун, Зүүн Сибирь рүү хуваарилна гэсэн яриа сургууль дээгүүр гараад байгааг хэлэх үү.

Юра инээмсэглэв.

–Манай ах надаас олон ах юм чинь би яаж түүнд нөлөөлөх вэ дээ?

Малькова ширээн дээрх цааснуудаа гүйлгэж харснаа хэрэгтэйгээ авч,

–Химийн аж үйлдвэрийн ерөнхий газар таныг аж ахуйн эрх зүйн ажилд авахаар хүсэлт ирүүлсэн байна. Энэ ямар учиртай юм бэ?

–Би дээд сургуульд орохоосоо өмнө химийн үйлдвэрт ажиллаж байсан, тэдэнд хуульч хэрэгтэй. Би үйлдвэртэй холбоогоо таслаагүй, тэгээд л тэд хүсэлт гаргасан биз.

Малькова хөмсөг зангидав.

–Цөмөөрөө л Москвад үлдэх санаатай. Тэгвэл орон нутагт хэн ажиллах юм бэ? Шүүх, прокурорын байгууллагад хэн ажиллах вэ?

Юра үг болгоноо цэгнэн зөөж,

–Шүүх прокурорын байгууллагад ажиллахын тулд итгэл хэрэгтэй, ямар ч өө сэвгүй нэртэй байх ёстой. Ах нь ялтан бол тийм итгэл яаж байх вэ дээ гэв.

–Шүүх, прокурорын байгууллагад ажиллахын тулд юуны түрүүнд жинхэнэ зөвлөлтийн хүн байх хэрэгтэй хэмээн Малькова сургамжлан өгүүлээд – Танай ахад тохиолдсон явдал чамайг тийм хүн байхад саад болж байна гэж үү? гэв.

–Намайг яагаад ахыгаа алдчихсан юм бэ? гэж та өөрөө асуусан шүү дээ. Түүнээс гадна боловсролтой хуульчид аж үйлдвэрт ч хэрэгтэй гэж би бодож байна.

Малькова босох зуур,

–Таны хэргийг би ерөнхий газрын даргад танилцуулна, дараа нь хуваарийн комисс бүх асуудлыг шийднэ гэв.

Юра ч бас босов.

–Намайг хааш нь явуулна, би тэнд очиж ажиллахад бэлэн байна.

–Тэгэхгүй яахав дээ, та оюутны цалин авч байсан, түүнийгээ эргүүлж төлөх хэрэгтэй шүү дээ гэж Малькова жишлэв.

–Би бол гарцаагүй Москвад үлдмээр байна. Энд миний эцэг эх гэж өвчтэй хөгшид байна, гэтэл би чухамдаа ганц хүү нь гэж Шарок дүрэлзэн өгүүлснээ ширээн дээр хэвтэж байгаа цаас руу зааж, – гэвч энэ бол үйлдвэрээс гарсан санаачилга. Тэдэнд химийн үйлдвэрлэл мэддэг хуульч хэрэгтэй гэсэн үг.

–Москвад үлдэх гэсэн хүн цөмөөрөө л ноцтой учир шалтаг олж байгаа, бас бүгдийнх нь нэр

дээр ийм мундаг хүсэлт бий гээд Малькова хэсэг зуур чимээгүй болсноо дараа нь гэнэтхэн – Харин танай сургуулийн намын байгууллага таныг өөр ажилд санал болгож байгаа. Эндээ гэж ярихад бас Москвад шүү гэж нэмж өгүүлэв.

–Надад энэ тухай мэдэх юм юу ч байхгүй... Чухам хаа юм бол?

–Сул орон тоо бий... Жишээ нь прокурорын газар. Гэвч та үйлдвэрт очихыг сонирхож байгаа шүү дээ? гэж хүүхэн тойруулсхийн хариулав.

–Тийм, би үйлдвэрийг илүүд үзэж байгаа. Би тэнд ажил хийж, тэнд өсөж бойжсон, тэндээс намайг сургуульд явуулсан. Би үйлдвэртээ маш их өртэй.

Юра үүнийг шаггүй дориун хэлсэн нь Мальковаг жаахан номхруулав.

–Бид таны санал, Химийн аж үйлдвэрийн ерөнхий газрын хүсэлтийн аль алиныг харгалзан үзнэ. За тэгээд комисс шийдвэрээ гаргана даа.

Ийм авгайгаас хувь заяа нь хамаарах гэнэ! Өөрөө аягүй бол тун саяхан Орехово-Зуевогоос ч юм уу аль нэг тосгоноос орж ирээ байлгүй. Гэтэл төрөлх Москвадаа байгаа мань хүнийг газрын мухар руу тонилгох гээд байгаа шүү! “Москвагаар нэг хөдөөгийнхөн дүүрчихлээ, хотынхон хаачих вэ? гэж асуумаар болж байна” гэж эцгийнх нь хэлдэг ч үнэн юм даа. Нэмэрт нь зүгээр ч үгүй, таныг Москвад, прокурорын газар ажиллуулахыг санал болгосон гэж егөөдөөд байгаа юм, худлаа хэлж байгаа байх... Үгүй ч юм болов уу... Мань хүн Москвад орон сууцтай, энэ байдлыг тэд харгалздаг шүү дээ.

Үнэхээр тийм санал тавьсан ч байлаа гэсэн энэ бол түүнийг энд авна гэсэн үг хараахан биш, ах чинь яагаад эрүүгийн хэрэгтэн байгаа юм бэ? гэж асууна. Жинхэнэ пролетари, ажилчны гэр бүлд эрүүгийн хэрэгтэн байх ёсгүй! Тэгэхлээр эднийх тийм айл биш, өтөнд идэгдсэн айл болж таарах нь. Өөрийн гэх өөр шалгарсан гэр бүл байхгүй гэж үү дээ?

Хүүхдийн бодлоор ургуулан бүтээсэн чөлөөт өмгөөлөгчийн сайхан дүр яваандаа бүдгэрч эхлэв. Шүүхийн амьдрал өмгөөлөгчийн сайн болон саар талыг харуулаад өгчээ. Тэрээр алдартай өмгөөлөгч нарын гайхалтай сайхан хамгаалж байгааг үзсэн төдийгүй цаадуул нь яаж үймэрч, хэрүүл уруул болж, яаж мөнгөний хойноос хөөцөлдөж, яаж шүүхийн нарийн бичгийн дарга хүүхнүүдийг зулгуйдаж, хуулийн зөвлөгөө өгөх газар тавхан цаасны хөлсөөр мулгуу авгай нарт зөвлөгөө өгөх гэж яаж зовж байдгийг үзсэн. Үйлчлүүлэгчийг явсан хойно хоолны өрөө, унтлагын өрөө болчихдог тэдний баян тансаг өрөөний үнэ цэнийг ч мэдэх болсон. Тэглээ ч гэсэн чухам ийм амьдрал л түүнийг даллан дуудаад байлаа.

Гэтэл бас хачин юм! Холбогдох байгууллагууд мань хүнийг бас л үл тоож ажилд авахгүй байх гэж бодохоос эгдүү нь хөдөлж, өөрснийхөндөө өндөр албан тушаал бэлдчихсэн байгаа, гэтэл мань эр гэж нэг дуулгавартай амьтан хамаг хар бор ажлыг нь нухах болно. Их л сайндаа хишиг төдийхнөөр хуураад үйлдвэр рүү явуулчихна. Нөгөө Будягины өширхөн хуулийн зөвлөх хэмээсэн газар руу явуулчихна.

Ардын комиссарын газар дуудагдсан тухайгаа Шарок хэнд ч хэлсэнгүй. Гэвч түүний

санааширсан байдлыг Лена анзаарчээ.

Тэр хоёр “Негрийг” үзэх билет арайхийж олоод театрт сууж байлаа.

Бүсгүй түүн рүү хайрын харцаар мишээж,

–Чи яагаа вэ? гэж асуув.

Цаадах нь инээмсэглэснээ хажуугийнхаа улсууд руу хяламхийгээд “Эдэнд битгий саад бол” гэв.

Гэртээ гарыг нь дэрлэж байхад сэтгэл нь юунд зовоод байгааг бүсгүй дахин асуув. Тэрээр онцын юм болоогүй, үйлдвэрийн газар руу хуваарилагдах нь жаахан төвөгтэй болж байна гэж хариуллаа.

–Чамайг хүсвэл би аавтай ярилцъя гэж Лена өгүүлэв.

–Иван Григорьевич чадах бүхнээ хийсэн.

Эцэг нь хийснээсээ илүү юм хийж чадахгүй гэдгийг бүсгүй ойлгож байсан тул өөрийнхөөрөө зүтгэсэнгүй.

–Өчигдөр Саша манайд ирсэн, түүнийг өрөвдөх юм гэж Лена хэлэв.

–Юу гээч болоо вэ?

–Чи мэдэхгүй гэж үү? Түүнийг комосмолоос, бас сургуулиас нь хөөчихсөн.

Хархүү тохойлдон өндийв.

–Анх удаа сонсож байна.

–Чи түүнтэй тааралдаагүй юу?

–Ойрд хараагүй.

Юра худлаа хэлжээ. Тэрээр Сашатай саяхан тааралдсан, харин цаадах нь түүнд юу ч яриагүй ажээ. Тэгээд Юра энэ тухай Ленад ярья гэсэнгүй.

–Нөгөө нэг явдлаас болж тэр үү? Нөгөө тоо бүртгэлийн багшаас!

–Тийм. Дараа нь бас ханын сониноос болж тэр.

–Мань эр ханын сонинд юу биччихээв?

–Нэг шүлгэрхүү юм бичсэн юм уу даа.

–Тэр шүлэг зохиодог гэж үү?

–Бичсэн юм уу, эсвэл хүний бичсэнийг тавьчихсан юм уу, мань эр яараад олигтой юм ярилгүй яваад өгсөн. Үнэхээр өрөвдөм шүү.

Саша Панкратов хөөгдчихжээ! Хичнээн үнэнч хүн билээ, гэтэл түүнийг сэгсэрчихэж! Нөгөө нугаршгүй, хатуу чанд идэвхтэн чинь одоо ингээд балардаг байжээ. Будягин хүртэл нэмэр болсонгүй. Нагац ах нь, нөгөө Рязанов, алдартай хүн! Аймаар юм байна. Сашкаг л ингэчихэж байгаа юм чинь...

Шарокт ямар нэгэн юм тохиолдох юм бол хэн түүнд туслахсан билээ? Оёдолчин эцэг нь үү? Ялтан ах нь уу? Мань эр бол Сашка шиг юм болгонд хошуу, хуруу дүрдэг хүн биш, гэлээ ч гэсэн... Прокурорын газар ажиллахаас татгалзсан нь дэмий юм боллоо, тэнд бол мань хүнийг хэн ч хөндөхгүй, харин өөрөө дуртай хүнээ хөндөнө, мань эрийн гараас мултрах хүн гэж даан ч байхгүй дээ...

Юра маргааш нь байшингийнхаа үүдэнд Сашатай яг мөргөлдчихөв.

–Мэнд үү!

–Сайн уу!

–Чамайг сургууль дээрээ эвгүй юм болсон гэж дуулсан, яачихаа вэ?

–Хэнээс дуулаав?

–Ленатай тааралдсан юм.

–Бүгд учир нь олдсон гэж Саша тоомжиргүй хэлэв.

–Өө тийм үү? За яамай л даа. Чи сургуульдаа түргэн буцаж орж амжжээ гэж Шарок дооглонгуй өгүүлэв.

–Амжсан. Би явлаа!

“Бүгд учир нь олдсон”. Саша ээжийгээ өчүүхэн ч болтугай ямар нэгэн сураг сонсчих вий гэж болгоомжлох учир Юрад хэлсэн шигээ бүх хүнд ингэж л хариулна.

Глинскаягийн тушаалыг товчооны хурлын маргааш хадсан байв. Түүгээр Сашаг “намын эсрэг хэргийн зохион байгуулагч” гэж сургуулиас хөөж, Руночкин Полужан, Позднякова гурвыг донгодож, Ковалёвт анхааруулсан байх ажээ.

Бөөн ажил дараалан дэгдэж бичиг баримт эрж хайн, элдэв лавлах, тодорхойлолт бэлдэцгээнэ. Янсоны оронд деканаар хэдийн томилогдож амжсан Лозгачёв Сашагийн дүнгийн дэвтрийг түргэн бараг уриалгахан янзалж өгөв. Түүний гөлчгөр царай би хувьдаа чиний эсрэг ямар нэгэн санаа байхгүй, ийм юм болсон хойно яая гэхэв, харин чамайг сургуульд сэргээн тогтоовол би үнэхээр баяртай байх болно гэж өгүүлэх мэт.

Саша ангийнхантайгаа цөмөөрөнтэй нь салах ёс хийж, гагцхүү Ковалёвтай л гар барьсангүй.

–Хорт могойнуудыг мэдэхийг ч хүсэхгүй байна.

Ковалёв үнэхээр хорт могой мөн, ер нь цөмөөрөө хорт могойнууд гэж Руночкин нотлон өгүүлжээ. Атигар хазгар Руночкин хэнээс ч айдаггүй билээ.

Хонх дуугарав. Байшингийн хонгил эзгүйрэв. Саша хэнд ч падгүй болов. Баримт бичгүүдээ авчихсан, тамга даруулчихаад яваад өгөх л үлдлээ.

Криворучко одоо хэр аж ахуй эрхэлсэн орлогч захирал хэвээр байв. Тэрээр тамга дарж өгөх зуур шивнээ дуугаар,

–Арван хоёрдугаар сарын зохих тодорхойлолтуудыг тасалбарын товчоонд явуулчихсан гэхэд Саша,

–Баярлалаа гэж хариулав. Тодорхойлолтыг уг нь хожуу явуулдаг юм чинь, зүгээр л Криворучко түүнд хүнсний тасалбаруудыг тавьж өгөх гэсэндээ ингэсэн хэрэг, өгөхгүй гэвэл чадах л шүү дээ.

Одоо ингэхлээр арванхоёрдугаар сарын эцэс хүртэл ээж нь ямар ч хар авахгүй. Тэр болтол сургуульд нь буцаагаад оруулчихна.

Нэг байгууллагаас нөгөө рүү сажлах, арга барагдан хаалга сахих, байдлыг тайлбарлах гэж зовлонгоо эдлэх, үл итгэсэн царайтай тулгарах, учрыг олно гэж худлаа амлах зэргийг бүгдийг үзлээ. Учрыг нь олъё гэх хүн ердөө алга, хөөсөн шийдвэрийг өөрчилнө гэдэг бол өөртөө хариуцлагыг нь авна гэсэн үг, гэтэл тэгдэг хүн хэн байх вэ дээ!

Районы намын хороон дээр түүний хэрэг Зайцева гэгч нэгэн залуухан царайлаг хүүхэнд таарчээ. Энэ хүүхэн нуруугаар намхан ч гэсэн сагсан бөмбөг сайн тоглодгийг нь Саша мэднэ. Тэрээр Сашаг нэгд нэгэнгүй сонссоны эцэст, яагаад ч юм бэ, Криворучкотой холбоотой, мань

хүний ойлгосноор хэдэн яльтай яльгүй юм асуугаад, ажиллаж байсан үйлдвэрээсээ тодорхойлолт олж авахыг зөвлөж, районы намын хороо, комсомолын хорооны товчооны хурлаар асуудлыг авч хэлэлцэх гэж байгааг урьдчилан мэдэгдэв.

Саша үйлдвэр рүү ойртохын үес өглөөний гудамжны шинэрсэн төрх, үүдээр цувран хүйтэн хөндий цех рүү хөвөрч буй хүмүүсийн урсгал, энэ тэр ямархан байдаг, яаж эртлэн босдог байсан зэргээ дурсан саналаа. Тэрээр техник нэг их сонирхдоггүй байсан ч гэсэн чухамхүү “пролетари” гэдэг үг, бас аугаа их хувьсгалч ангийн эгнээнд байх явдал дур татан дуудсан учир үйлдвэрт ажиллахыг хүссэн билээ. Амьдралын үл мартагдах бадрангуй эхлэл.

Түүнийг очсон өдөр нь л вагон яаралтай ачаалах ажилд явуулжээ. Тэрээр татгалзвал болох л байсан, жишээ нь Юрка Шарок тийм ажлаас татгалзаад механик цехэд зорогчийн дагалдангаар орсон. Гэвч Саша яв гэсэн газар руу нь яваад өгсөн, тэгээд л түүнийг цөм мартжээ. Хэн нэгэн хүн вагон ачиж байх ёстой учраас Саша өөрийнхөө тухай сануулж хөөцөлдсөнгүй. Тэгэхэд амьдрал эцэс төгсгөлгүй, хамаг юм цаг нь болоогүй, цагаа болохоор бүх юм хүрээд ирэх мэт санагддаг байжээ. Бэржээнтэн хүрэм, бэржээнтэн бээлий углачихаад цас бороо, халуун хүйтнийг алиныг ч эс ажран, барааны хашааны задгай талбай дээр вагон ачиж, буулгаж тийнхүү улс орондоо хэрэгтэй энэ нэгэн ажлыг хийж, саруулхан бөгөөд дулаахан цехэд аяа олсон цэвэрхэн Юркаг үзэн ядна.

Тэднийхэн бүх бригадаараа гуанзанд нөмрөн орж ирэхэд хүрэм, хөвөнтэй цамц нь будаг, шохой, гөлтгөнө, нүүрс болчихсон тэднээс хүмүүс дөлөн зайлна. Мань эрчүүд шуугилдан хараал тавина. Эдийн засгийн шинэ бодлоготой санал зөрсөн учир намаас гарч хожим архинд орсон, урьд нь дивизийн хомандлагч байсан Морозов гэдэг номхон хүнийг Саша санаж явна. Тэдний бригадын дарга байсан Аверкиев гэдэг хүн авгай нь салаад явчихсан учир архичин болсон, мөн тиймэрхүү амьдралынхаа замыг алдсан хэд хэдэн хүнийг санаж байна. Тэд нар мөнгөний хойноос хөөцөлддөггүй, хугас шил архины мөнгө олсон л бол болоод явчихдаг хүмүүс боловч хийснээрээ авдаг ажлаас зайлсхийж, ажлын хөнгөнийг шилэхдээ аравны дарга, тоо бүртгэгч энэ тэртэй байнга зөрж, цагаар цалинждаг ажлыг урьтал болгохын дээр тодорхой нэг юм хийчихээд яваад өгч болдог ажилд бүр ч дуртай. Тийм ажил таарвал гагцхүү эртхэн алга болохын тулд хамаг хүчээ гарган шуурхай ажиллацгаана. Саша тэднийг жинхэнэ ажилчин гэж үздэггүй боловч бүтэл муутай хувь заяатай тэдний сэтгэл хөдлөм нэгэн хүнлэг чанар гэлтэй нэг юм өөриймсөг санагдана. Ажлын даалгавар авахдаа залилах гэж байдгаараа оролддог хэрнээ хоорондоо бие биеэ хуурах буюу ажлыг нөгөө рүүгээ түлхэнэ гэж заяа нь байхгүй. Саша хэдийгээр тэдний архидахад оролцдоггүй, зах зээлийн шог ярьдаггүй, элдэв заваан марзан домог ярьж уралддаггүй ч гэсэн цаадуул нь мань хүнтэй бүлэрхэн харьцана.

Энэ эрээвэр хураавар шаарлагдсан бригадыг голдуу л аар саархан ажилд гаргадаг боловч заримдаа бэлэн бүтээгдэхүүн болох торхтой будаг вагонд ачих гол ажилд гаргана. Хоосон вагон мөд ирэхгүй удсанаас болж торхтой будаг барааны хашаан дотор тэвхийтэл овоорох явдал гардаг авч гэнэтхэн бөөн бөөн вагон шилээ даран ирэхэд бүх бригадыг түүний дотор Сашагийн ажилладаг Аверкиевийн бригадыг будаг ачих ажилд гаргана.

Торхтой будгийн жин наян кило. Түүнийг налуу дамнуургаар өнхрүүлж вагонд оруулаад нэг эгнээ дүүргэж дээр нь дахин хоёр давхарлаж өрнө. Дамнуурга нэлээд огцом учраас хар эрчээр нь түүн дээгүүр хүчлэн өнхрүүлж, орсон хойно нь дотор нь эргүүлж, тогтоосон тоо

хэмжээгээр нь багтаахын тулд бие биед нь сайтар тулгаж тавина. Найман цаг нуруу тэнийхгүй, нэг нь наян кило хүнд торх өнхрүүлж түүнийг огцом дамнуургаар авч гараад босгож тавилна гэдэг бол бэрх ажил. Түүнээс гадна араас чинь нөгөө нөхөр чинь гүйж яваа учраас яарах хэрэгтэй, тэр хүн бас л эрчээр нь дээш нь гаргаж байгаа юм чинь огцом дамнуурга дээр хүлээх арга байхгүй, хэрвээ чи өөрийнхөө торхтой хором төдий л саатлаа бол бүгдээрэнд нь тушаа болж ажлын хэмийг алдуулна. Саша эхлээд торхыг яг байх газарт нь онож байрлуулж чадахгүй байв. Хоёр гараараа торхны дээд талаас барьж огцомхон өргөж хазайлгаад ирмэг дээр нь эргүүлж зохих газарт нь тавьдгийг түүнд зааж үзүүлжээ. Ингэж үзүүлснээс хойш Саша хэнд ч тээр болохоо больжээ.

Будаг ачих ажил дээр голдуу хоёр гол бригад ажиллана. Нэг нь мөнгө хөөж Ульяновск мужаас ирсэн татарууд, нөгөө нь олигтойхон олохыг эрмэлзсэн мэргэжлийн орос ачигчид. Будаг ачихад хөлс нь тун сайн.

Аравны дарга Малов нэг удаа ажил хуваарилж байх үеэр,

–Аверкиев, нэгдүгээр бригадад нэг хүн өгчих, тэднийхний нэг нь өвдчихсөн байна гэв.

–Чи оч гэж Аверкиев татар Гайнуллинд хэлэв.

–Би явахгүй гэж Гайнуллин өчив.

–Лившиц!

Лившиц гэдэг нарийхан духтай, одессийн нүсэр том еврей,

Цаадуул чинь гахайн мах иддэггүй болохоор би тийшээ явж болохгүй гэж тоглоом болгож өнгөрөөв.

Чингэмэгц Малов.

–Та нарын ном хаялцахыг чагнаж байх цаг надад алга. Хүн гаргахгүй бол би өөрөө томилно гэж хэлэв.

Малов бол халагдсан салаан дарга басхүү өөрөө ачигч хийж байсан, эрээ цээрээ алдсан Аверкиевийн бригадыг хүртэл эрхэндээ оруулж дөнгөсөн бөх гэмээр шийдэмгий хүн.

–Томил гэж Аверкиев хариулав.

Маловын харц Саша дээр тогтов.

–Панкратов, нэгдүгээр бригад руу оч!

Малов Сашад нэг л дургүй. Магадгүй, боловсролтой ачигчид түүний сэтгэлд таардаггүй байж болно. Саша есдүгээр анги төгссөн болохоор энд хамгийн их боловсролтойд тооцогдоно. Энэ удаа Малов түүнийг бас л дургүйцнэ гэж санаад асуух, жигших хослон харж зогсов. Гэтэл Саша,

–Тэгье, би явна аа гэв.

–Нүх сүв болгон руу шургаж байх юм гэж Аверкиев дургүйцэн өгүүлэв.

Татарууд торхыг өнхрүүлэхийн оронд үүрч зөөнө. Эхлээд модон замаар дараа нь дамнуургаар бушуухан гүймэглэж вагонд ормогц торхоо яг зохих байранд нь тавина. Энэ нь түргэний хувьд түргэн ч шал өөр ёстой тэсэшгүй бэрх ажил. Наян кило жинтэй бөөрөнхий торх үүрч, намалзсан модон замаар огцомхон дамнуургаар шогшуулж, тэгээд хөлөө цохичихгүй, яг байрлавал зохих газар нь буулгахын хамт өглөө ээлж эхлэхэд араас нь гарсан хүнийхээ хойноос өдөржин дагаж гүйнэ гэдэг үнэхээр хүнд. Нөгөө торх чинь нуруунаас юу юугүй мултарч, өөрийг чинь хамтдаа татаад унагачих нь уу гэлтэй болоод ирнэ, гэвч хормын төдий ч зогсож болохгүй, арын чинь хүний хөлийн хэм, давхцсан амьсгаа энэ тэр мэдэгдэн, хөлснийх нь үнэр ханхлаад чи зогтуслаа л бол нөгөөдөх чинь нөмрөөд авна гэсэн үг. Ийм болохоор чи хамаг хүчээ шавхан зүтгэж, нөгөө л гүйсэн эрчээрээ дамнуургыг гэтлэн вагонд шогшуулж ормогц торхоо буулгачихаад хэнийг ч энэрч үзээгүй, тэгэх тусмаа чам шиг хөндлөнгийн хүнийг ёстой тоохгүй туршлагатай чийрэг ачигчдаас хоцрохгүйн тулд буцаад л бушуухан харайлгана.

Үдийн хоолны яндан дуугарах нь тэр! Саша хураалттай торхнуудын дэргэд лагхийтэл унав. Нүдний нь өмнө улаан улаан дугуй цагирагнууд эргэлдэж толгой нь тэр аяараа шуугин янгинана.

Саша нэг зүүрмэглэж, нэг сэрнэ. Тэгээд сэрэх тоолондоо эндээс босож, нөгөө өглөөнөөс хойш дагаж яваа лухгар шар татарын шил рүү шагайж, дахиад л торхоо үүрэн ганхсан дамнуургаар шогшуулж эхлэх мөчийн тухай л бодно. Дахиад дөрвөн цаг ингэж ажиллаж дөнгөхгүй, дамнуурга дээр тэрийгээд унаад өгнө гэдгээ мэдэж байлаа.

Тэрээр конторт очиж, мэргэжил эзэмших гэж ийшээ ирснээс биш наян кило торх үүрэх гэж ирээгүй, тусгай шийдвэрээр үйлдвэрлэл рүү, үйлдвэрийн цех рүү явуулсан гэж заргалдвал болох билээ. Энэ бүхэн чөтгөр шулам руугаа тонилбол таарна! Яаралтай ажил гэхээр нь сайн дураараа явсан чинь хүнийг тэр чигээр нь ачигч болгоод хадчихаж байна... Мэдээж, ингэж заргалдвал заргалдах л даа. Гэвч яндан дуугармагц мань эр нөгөө шар татарынхаа араас зогсож, ууцаа өгөөд торхтой будгаа вагон руу аваад явна гэдгээ яг мэдэж байлаа.

Ажилчид гуанзнаас буцацгааж байхыг үзвэл завсарлага удахгүй дуусна гэсэн үг. Саша зориг хүчээ хөвчлөн байж өндийн суугаад гар хөл, толгой түрүүгээ хөдөлгөв. Хамаг бие нь шархирч, бүх эрхтэн нь хүнийх юм шиг санагдана.

Түүнийг дуудах шиг болоход толгой өндийж харвал бригадын дарга Аверкиев, дивизийн хамаандлагч асан ачигч Морозов хоёр дэргэд нь зогсож байв. Тэр хоёр үдийн хоолон дээр балгасан бололтой. Аверкиевийн сэлхэрсэн царай час улайж, Морозовын цэнхэр нүд улам цэнхэртэн, гэрэл мөрөөсөл хослон байна.

–Зажилчих! гээд Аверкиев талхны хэлтэрхий, хэрчим хэрсэн өвөр рүү нь хаяв.

–Баярлалаа.

–Торхыг нурууныхаа энгээр бүх ууцныхаа дагуу тавьж бай ойлгов уу? гэж Аверкиев хэлээд, – Алив нэгийг хаяад орхи! гэв.

Тэрээр бөхийн зогсоод хоёр гараа ардаа тосоход Морозов, Саша хоёр нуруун дээр нь нэг торх тавьж өгөв. Торх яг ууцыг нь дагаад тэгшхэн тогтжээ.

–Гэтэл чи ингэж байна! гээд Аверкиев биеэ сэгсэрсэнд торх дээшлэн сэрвээн дээр нь гарч, мань хүн хоёр гараараа урд талаас нь барьж авав.

–Сэрвээн дээрээ зөөх чинь буруу, ууцан дээрээ зөө. Үз дээ!

Саша бөхийн ууцаа өгөв. Аверкиев, Морозов хоёр түүнд нэг торх үүрүүлээ.

Юу гэж сэрвээгээ доошлуулаад байгаа юм бэ? гэж Аверкиев хашгирав.

Саша сэрвээгээ өндийсөнд торх ууцыг нь даган жигдхэн наалдаж байраа оллоо.

–Яг ингээд зөө! Өөрөө дурласан хойно зөөж л бай!

Одоо торх нь доошоо гулсаад байхгүй, хамаагүй тогтвортой болсон нь өөрт мэдэгдээд ирлээ. Гэвч хүнд нь дарсан хэвээрээ, хоёр хөл нь гуйвална. Буулгачихаад буцаж шогшох хооронд ууц нь буцаж тэнийхгүй болжээ. Үдээс хойшхи ээлжийг мань хүн яаж тэсэж өнгөрүүлснийг бүү мэд, яаж байрандаа ирсэн нь ч бүү мэд, орон дээрээ ойчоод өглөө болтол нам унтжээ.

Гэтэл өглөө Малов,

–Нэгдүгээр бригадад дахиад хоёр өдөр ажилчих, дараа нь чамайг шилжүүлье гэж хэлжээ.

Саша будган дээр хоёр долоо хоног ажиллаж, торхыг нэгэнт зөөж сурчээ. Татарууд нь мань хүнд дасаж, өөрөө ч тэдэнд дассан төдийгүй албан татвартай холбогдуулан тосгоны зөвлөлд гаргах өргөдлийг нь хүртэл бичиж өгөх болж гэнэ.

Тэрээр хуучин бригадаа эргэж ирсэнгүй. Түүнийг ачааны машины ачигчаар гарааш руу явуулав.

–Жолооч болох сургууль хий гэж Малов хэлжээ. Харин Сашаг баярлуулах гэсэндээ юу, эсвэл түүнээс салах гэсэндээ юу гэдэг л ойлгомжгүй байлаа.

Саша гараашид ажиллах зуур жолооч болж амжаад машинаар явах болжээ. Гэвч энэ удаа үйлдвэр лүүгээ очиж явахдаа, яагаад ч тэр юм бэ, чухамхүү яаж ачигч хийж байснаа дурсан санав. Энэ нь түүний үйлдвэрт байсан хамгийн анхны, сэтгэлд хамгийн их хоногшин үлдсэн сарууд байжээ.

Энд хэнтэй тааралдах бол? Хуучин цуг байсан залуусаас нэг ч хүн байхгүй биз дээ. Үгүй, байгаа ч юм билүү, ямар нэг их удаан хугацаа өнгөрсөн биш, дөнгөж дөрөвхөн жил юм чинь.

Үүдний хуучин модон пинг буулгаж өөр газар туйпуугаар томыг барьжээ. Бас хашааны

хаалгыг өөр газар зөөж, чулуун өрлөгтэй өргөн хаалга хийжээ. Үйлдвэрийн захиргааны шинэ барилгыг талбай руу харуулж барьсан харагдана. Өндөр хэрмэн хашааны цаанаас үйлдвэрийн шинэ шинэ барилга сүндэрлэнэ. Талбайг хатуу хучлагаар цардаж, тэнд дэлгүүр, мухлагууд бий болжээ. Үйлдвэр ажиллаж, өсөж барилгажсаар байна. Энэ бол улс орны зүрх судсыг тодорхойлж байгаа жинхэнэ юм мөн. Мань хүн ч гэсэн юуг ч эс харгалзан ийм л юмаар амьдрах ёстой!

Намын байгууллагын нарийн бичгийн дарга нь Малов байх ажээ. Нэг их таатай бус сонин! Барааны хашаанд ажилчдыг захирч байсан үеийнх шиг хацар нь улаа бутрахаа больж турж эцэн, царай шаргалтан, үс халзарсан боловч нөгөө л бөхтэй төстэй хэвээрээ. Хуучин ажлын хуудсан дээр гарын үсэг зураад цонхны тавиур дээр сууж байдагтайгаа адилхан бичгийн том ширээний цаана буландасхийгээд жишүүхэн суужээ. Тэрээр Сашаг даруй танив. Тэгээд энэ дөрвөн жилийн хугацаа өнгөрөөгүй, Саша урьдын адил үйлдвэртээ ажилласаар байгаа мэт,

–Өө Панкратов... чи юу гэв? гэж асуув.

Саша хэрэг явдлаа ярилаа.

–За яахав, би товчоон дээр байна. Тэгээд юм хэлнэ ээ... гэж Малов өгүүлэв.

За тэр зайлсхийлээ, тодорхойлолт хийж өгөх дургүй байх нь...

–Зайцева намайг тодорхойлолт бичгээ авчраарай гэсэн юм.

–Цаас л хэрэгтэй байх нь л дээ гэж Малов үглэснээ – За яахав, би биччихнэ. Хаа ажиллаж, юу хийж байснаа нэг сануулаад орхиоч гэв.

Тэрээр Сашагийн нэрлэсэн ажлуудыг тэмдэглэж авснаа түүн рүү харж,

–Яаж ийж байгаад зоогдчихов? гэж дооглонгуй асуув.

–Яагаад “яаж ийж байгаад” байх билээ?

–Нэг л тэгэх царайтай байсан юм. За яахав.

Цаг хэрэгтэй явж байгаад ир, тодорхойлолтыг чинь зохиоё доо.

–Би үйлдвэр рүү орж нөгөөдүүлтэйгөө уулзмаар байна...

Үйлдвэрийн төв хэсэг хэвээр үлдэж, шинэ барилгануудыг зайдуу барьж байгаа ажээ. Нэг, хоёр, гуравдугаар цех, механик цех, уурын зуух, за гарааш маань энэ байна... Засварын нүхэн дээр даргын хар “форд” байна. Даргын жолооч Сергей Васильевич дархны вандангийн дэргэд зогсож байгаа харагдана. Тэр ч Сашаг бас танилаа.

–Үйлдвэртээ эргэж ирээ юу?

–Хэрэг гараад ирлээ.

Сергей Васильевич хар савхин костюм, тугалган малгай, галоштай нарийн эсгий гутал өмсөнө. Тэрээр бие бадриун, дураараа ихэмсэг дүртэй, бүр хувьсгалын өмнөөс жолоо барьсан, даргын ойр дотнын хүний нэг билээ.

Ийм олон юм мартагдчихсан, тэгээд сая энд ирж үйлдвэрийнхээ дуу чимээг дахин сонсож, цех зам зөргийг нь дахин харахтайгаа зэрэг санаанд тэр болгон орж ирж байгаа нь хачин юм. Тэр үед бодох санах юмгүй амар байжээ. Ажлаа хий, цалингаа ав, комсомолын даалгаварыг биелүүл, ерөөсөө л энэ шүү дээ. Хэн нэгэн хүнд улс төрийн хэрэг тохож байсныг мань хүн ер санахгүй юм. Энд бол бүтээгдэхүүн гаргана, үйлдвэр барина. Гэтэл одоо энд ч бас юм өөр болчихсон юм болов уу? Малов ямар тодорхойлолт хийж өгөх бол оо?

Малов дараах тодорхойлолтыг хийж өгөв. “Панкратов А. П. 1928-1930 онд тус үйлдвэрт эхлээд ачигчаар, дараа нь жолоочоор ажиллаж байсныг үүгээр тодорхойлов. Ажилд үнэнч ханддаг, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлдэг байсан. Тээврийн цехийн БХЛКЗЭ-ийн үүрийн нарийн бичгийн даргын хувьд олон нийтийн ажилд оролцож байв. Арга хэмжээ байхгүй”.

–Товчоон дээр байх юм чинь хэрэгтэй юм байвал нэмээд хэлчихнэ гэж Малов амлав.

Саша үйлдвэрээс буцаж ирэхдээ шуудангийн хайрцгийн нүхээр хөх дугтуй харагдахыг үзэв. Эцгийнх нь захидал, бичиг нь мөн байна. Түүний захидлууд хэзээ ч баяр авчирч байгаагүй. Эцэг нь технологийн лавлахууд явуулахыг хүсжээ. “Тэр лавлахууд шүүгээний доод тавиур дээр бий, доод тавиур хаана байгааг чи мэднэ биз дээ. Ийм юм хүсэж чамд төвөг удмааргүй санагдавч өөр гуйх хүн даанч алга. Тэрийг авах гэж Москва руу явах ч хаашаа юм бэ... Намайг очлоо гэж баярлах хүн байх биш”.

Эцэг нь дандаа ингэж ярьдаг болохоор дуу нь сонсдох шиг болов. Ээж нь түүнээс “хоол идсэн үү?” гэж асуухад “Идэхгүй ч байсан болно” гэж хариулна. “Чи хуралд явлаа юу?” – “Би бүжигт явлаа” Чих нь жаахан хатуу учраас гүйцэд сонсоогүй юмаа өөрийнхөө тухай ярьж байна гэж бодоод хараал тавина. Өглөө нэг алим эсвэл орой нэг аяга тараг өгсөнгүй гэж зүхэлдэнэ. Ирж яваа хөлийнх нь чимээ байшингийн хонгилд гарангуут ээж нь айсандаа дуугарч чадахаа больчихно. Тэрээр ажлаас эргэж ирэхдээ л гэр орон, авгай хүүхэддээ хэзээний сэтгэл дундуур, өөлөх, загнах, хэрүүл дэгдээхэд бэлхэн орж ирнэ.

Ээж нь гагцхүү хардах үедээ л түүнээс айхгүй. Тийм үед гэрт нь бөөн дуу шуугиан хадаж хаалга тас нясхийн, эх нь хорсон бүлтгэнэж уйлж бахирахад Сашагийн зүрх шимшрэн арга барагддаг билээ.

Эцэг нь даруй зургаан жил тэднээс тусдаа аж төрж байгаа аж. Гэтэл ээж нь түүнээс алсын зайд хүртэл урьдын адил айна. Одоо ч гэсэн түүний захидлын бараанаар нөгөө л айж түгшсэн байдал царайд нь тодроод ирлээ.

–Ааваас чинь ирж үү?

–Лавлах явуулаач гэсэн байна.

Софья Александровна айсан чигээрээ захидлыг авч уншиж дуусан дуустлаа царайд нь хурсан айдас хэвээрээ байлаа.

Өөрийнх нь тухай бүх юмыг мэдсэн цагт ээж нь яадаг бол гэж Саша юм юмнаас илүү айна. Тийм ч учраас ээждээ юу ч мэдэгдэхгүйн тулд юу ч болоогүй юм шиг дүр гаргана. Сургууль руугаа явж байгаа янзтай гэрээсээ гарна. Киевийн ачааны буудал дээр вагоны ачаа буулгаж арван хоёрдугаар сарынхаа оюутны цалинг нөхөж олсон. Цаг нөгцөөх газаргүй болсон цагтаа Нина Ивановнагийн руу тавьж хүрнэ.

Тэр хүүхэн Сашад байрныхаа түлхүүрийг өгсөн тул өглөөд тэднийд очиж юм унших буюу хичээлээ хийнэ. Тэгж байтал Нинагийн дүү охин Варя сургуулиасаа буцаж ирнэ. Тэрээр хар пальтотой, жижигхэн шаахайтай, алчуураа замдаа тайлчихсан, шулуухан задгай хар үс нь пальтоныхаа захан дээгүүр намиран орж ирж, орон дээрээ хөлөө ачиж суугаад, памбагар уруулаа цорвойлгон нүүр рүүгээ унжсан үсийг дээш нь үлээчихээд арван таван настай хөөрхөн охидын банди нарыг ичээдэг харцаар Сашагийн нүд рүү эгцлэн харна.

Цоохортон хуурсан хулдаасан бүтээлэгтэй ширээ тасалгааг хоёр хэсэгт хуваана. Нинагийн

хэсэгт ширээн дээгүүр замбараагүй орхисон ном, дэвтэр, орон доогуур нь элээж гүйцсэн гэрийн шаахай, Варягийн хэсэгт дэрээ бүтээсэн тодхон өнгийн алчуур, цонхны тавиур дээр тавьсан эгшигт хайрцаг, сунгасан булчинт гартаа чийдэн барьсан тамирчны хүрэл цутгамал энэ тэр бий.

–Чамайг яасан гэж сургуулиас чинь хөөчихсөн юм бэ?

–Буцааж авнаа.

–Би бол цаадуулыг чинь өөрсдийг нь цөмийг нь хөөчих байсан юм, манай сургуульд ч гэсэн хүний мууг үзэх гэж улы нь шагайхаас өөр юм мэддэггүй адгийн амьтад бий. Өчигдөр манай ангийн хурал болсон юм, тэгсэн чинь Лякин “Иванова будаа идэх юмаа өвдгөн дээрээ бичдэг” гэж байхгүй юу! Би хөлөө сунгаад “Тэр будаа чинь хаа байна?” гэж асуулаа.

Варя ангидаа яаснаа үзүүлж хөлөө сунгаж харуулав.

–Тэгсэн чинь тооны багш Кузя улаан лооль шиг час улайгаад, Иванова болиоч! гэж байна. Уул нь надад ямар хамаа байх билээ? энэ чинь Лякины хийж байгаа хэрэг. Ноднин охидын цүнх булааж авч сахилгагүйтсэн этгээд байсан юм, гэтэл энэ жил сурагчдын зөвлөлд орчихсон. Өөрөө адилхан хуулна, тийм мөртлөө бусдыг ховлоно. Тийм улсыг би үзэж чаддаггүй юм.

–Чи “будаагаа” яаж хийдэг вэ?

–Тун амархан хэмээн охин даавуун оймстой өвдгөө алгадаж – Хортой харандаагаар бичдэг юм гэв.

–“Будаа” идэхгүй байж чадахгүй юу?

–Чадна, гэхдээ тэгье гэдэггүй юм.

Тэрээр өвдгөө ил гаргаж, тэрүүхэндээ хэвлүүхэн оргиод Саша руу өдсөн янзтай харах ажээ. Сашад инээдэмтэй байвч Варя эгчдээ хичнээн төвөг уддагийг мэдэх тул аль болохоор төв байхыг хичээв.

Хоёр охин эцэггүй өсөж бойжсон, хожим нь бас ээж нь нас барсан билээ. Саша нэг товчооны хурлыг санаж байгаа. Тэр хурлаар дүүгээ хүмүүжүүлэхэд нь Нинад яаж туслахыг хэлэлцэж, түүнд тэтгэвэр олгуулахаар шийдсэний гадна цалинтай пионерийн удирдагч болсон билээ. Хожим сургуулиа төгсөөд тал тал тийшээ тарцгаасан, тэгээд Варя үе үе тэнгийнхэнтэй хашааны үүдэн дээр миегнэлдэж байхад нь нэг удаа тааралдаад түүний тухай санасан аж.

–Чи комсомолын гишүүн үү?

–Яах юм бэ?

–Үүдээр холхилдож байсан нь дээр үү?

–Надад аятайхан л байдаг юм.

–Гэртээ хонодоггүй байна

–Ха-ха! Нэг удаа зусланд, найз охиныдоо хоносон, галт тэрэгний буудал руу явахаасаа айгаад. Нинка өөрөө ч гэсэн шөнө бол явахгүй л байсан даа, тэр чинь надаас ч аймхай, зуу дахин аймхай. Тэр Макстайгаа л суувал таарна, бас юу ч хийж чадахгүй, Максад нь юу ч хэрэггүй л дээ, тэр хоёр гуанзаар л хооллоод байх улс.

–Ийм зөвлөгөө өгөх чинь чамд эртдэж байгаа бус уу?

–Тэгвэл тэр ч гэсэн миний явдалд оролцохоо боливол таарна. Хоосон шуугихаас өөр нэмэр байх биш.

–Чи юу болох хүсэлтэй вэ?

Охин хариулахын оронд хүүхдийн цангинасан хоолойгоор ийн дуулав:

Ээрэм талын цэцэгхэн чиний минь

Инээх дуун бишгүүрээс яруухан.

Хонгилд хонх жинхийв.

–Нина ирлээ, түлхүүрээ бас л мартчихаж хэмээн Варя суусан чигээрээ өгүүлэв.

–Нина гэж чи яаж мэдэж байгаа юм бэ?

–Манайхны хэн нь яаж хонхдогийг би андахгүй.

Нина орж ирээд Варя орон дээр өвдөг нь ил сууж байгааг үзмэгц эх захгүй, даруулгагүй байна гээд эхэлчих нь тэр.

–Толгойд нь банди нар, хумсны лак, уруулын будгаас өөр юу ч байхгүй. Зүгээр ч үгүй лууван шиг өнгөтэй будаг, их юм мэдэж дээ. Хэдэн цагаар толины өмнө зоогдчихоод хоолны хутгаар сормуусаа матах гээд ноцолдчихно.

–Хутгаар аа? гэж Саша гайхав.

–Эсвэл утаснаас зүүгдчихнэ. Гагцхүү хар хив, тансар хилэн, улаан саат, цэнхэр торгон... гэх мэтийн юм л сонсогдоод байх нь тэр. Би ганц цамцаа таван жил өдөр болгон угааж өмсөж байна, тэглээ ч гэсэн чухам ямар бөсөөр хийснийг нь одоо хүртэл мэдэхгүй. Гэтэл миний дүү даашинздаа таарсан товч олох гэж гурван өдөр дэлгүүр хэсэж байна. Галош өмсөх ёсгүй гэнэ, эсгий гутлыг ад үзнэ. Миний гоёлын шаахайг хулгай хийж, бүжгэнд очиж юу ч үгүй талхалчихаад угаалгын өрөө рүү авчираад хаячихсан байгаа юм. Өнөөдөр шаахай, маргааш мөнгө авна, тэгээд надад мөнгө байхгүй юм чинь хулгай хийхээр явна.

–Битгий айлга! Өөрийгөө ч битгий айлга, энүүнийг ч битгий айлга гэж Саша өгүүлэв.

Гэтэл Варяд эмээсэн юм огт үгүй байжээ. Худлаа эвшээлгээд энэ бүхнийг сонсохоороо нэг сонссон, хэдэн зуу дахин сонссон гэх мэт харц нь тээршээж залхсан байдалтай болов.

–Энэний хэрцгийг гайхаж цөхөөд ойлгохгүй юм. Максимыг дооглоно. Тэр үүнд ямар хамаа байна? Өөдгүй, хүмүүжилгүй явдал.

–Макс уруу царайтай л даа гэж Саша эвийг бодож өгүүлэв.

Нинагийн харц барайгаад явчихлаа.

–Би Максиг үнэлдэг юм, ёстой гэмгүй сайн залуу. Гэтэл би юу бодох ёстой билээ? Би үүнийг бас хөл дээр нь босгох хэрэгтэй.

–Над руу чихэхийн хэрэггүй шүү дээ гэж Варя хэлэв.

–Ханын сонин гаргах даалгавар өгсөн чинь энэ нөхөр хажуугийнхаа ангид ороод сонины нь үг үсэг алдалгүй хуулчихсан, тэр ч байтугай залхуураад хүнийх нь нэрийг хүртэл өөрчлөөгүй гэж байгаа. Ийм хүн юу болох, ямар юм үүнийг хүлээж байна?

Варя шаахайгаа хөлөөрөө тэмтэрч олж өмсөөд бослоо.

Ээрэм талын цэцэгхэн чиний минь

Инээх дуун бишгүүрээс яруухан...

Саша районы намын хороо руу сэтгэл тайван очжээ. Бүх асуудлыг шийдэхээс айхгүй байгууллага бол чухам энэ. Хуралдааныг нэгдүгээр нарийн бичгийн дарга Столпер даргална.

Саша дуудахыг хүлээн хонгилд нэлээд удаан суув. Хаалганы цаанаас хүмүүсийн дуу, зарим нэг яриа сонсдовч нэг чанга ширүүн дуу бүгдийн яриаг тасдаж, дундуур нь орж, ярихыг болиулж байх ажээ. Айсан хүмүүс тасалгаанаас ухас хийн гарч ирж, шүүгээ сав руу харайлган, хавгастай юм шүүрэх зэргээр сандарч, нөгөө утсаар чанга дуу араас нь сонсоно. Столпер энэ түшмэдүүдийг ингэж илдэж байгаа нь Сашад аятайхан санагдана. Саша дайсны хаяг зүүсэн Баулин болоод бусад этгээдийг цөмийг нь ингэж элдэх болно.

Хаалга дутуухан нээгдэв.

–Панкратов!

Хүн олон цуглажээ. Нэг хэсэг нь хана даран, нөгөө хэсэг нь ногоон цэмбэн бүтээлэгтэй ширээ тойрон сууцгаажээ. Столпер гэж ядарсан хүйтэн харцтай туранхай хүн Саша руу ширүүн хараад Зайцева руу дохиж,

–Илтгээрэй! Товчхон шүү гэв.

Зайцева хичээнгүй сурагчийн дуугаар хэргийн материалыг танилцуулав. Түүнийг шоглол шүлэг уншиж байхад нэг хүн инээд алдав. Шоглол шүлгүүд тун болхи нь мэдэгдэх ажээ.

Дараа нь Зайцева энэ бүх баримт сэлтийг гол юмтай нь холбож үзвэл зохино гэж хэлэв.

Эндээс л Криворучко эсэргүүцлийн бүлгийн хүн байсан гэдгийг Саша анх удаагаа олж сонсов. Чухам ямар эсэргүүцлийн бүлгийнх гэдгийг Саша ойлгосонгүй. Зайцева эхлээд намын арван нэгдүгээр их хурал, “ажилчны эсэргүүцлийн бүлэг”, дараа нь Криворучкогийн гарын үсэг зурж Төв хороонд явуулсан хамтын захидал гэгчилэнгийн зүйлийг дурдсан боловч юун захидал байсныг нь хэлсэнгүй. Тэгснээ Криворучко холбоогоо таслаагүйн учир тухайн үедээ намаас хөөгдөж байсан гэж мэдээлэв. Хэзээ, хэнтэй, ямар холбоотой байсныг бас хэлсэнгүй, харин түүнийг намд нь эргүүлэн тогтоож, донгодож шийтгэсэн гэдгийг нэмж хэлэв. Хожим энэ нөхөр төмөр замыг нийгэмд харш, ангийн дайсан этгээдүүдээр бохирдуулсны учир дахин донгодуулсан. Ямар зам, Криворучко тэнд юу хийдэг байсныг Зайцева бас дуугүй өнгөрөв. Тэгтэл намаас дахин хөөгдсөн байна, энэ удаа барилгын ажил тасалдуулсны учир. Намаас хөөгдсөн, донгодуулсан арга хэмжээний жагсаалт Криворучкогийн хувийн хэрэгт байсан атал Зайцева гэгцхүү сурах бичигт л бичээтэй байдаг гэмт хэрэгт холбогдон ийм хүнийг илрүүлсэн сэтгэл ихэд догдолсон, чухамхүү энэ хүнийг өөрөө л илрүүлж улайлгасан дүртэй ярьж байлаа.

Саша Зайцеваг сонсох зуур Криворучкогийн хэрэг тийм ч яльгүй зүйл биш гэдгийг ойлгож суув. Криворучко урьдынхаа хэрэгт орооцолдчихжээ. Харин энэ бүхэн түүнд, өөртэй нь ямар холбоотойг Саша ухаарч чадсангүй.

Столпер Сашагийн хавгаст хэргийг авч гүйлгэж харав. Цөм чимээгүй сууна. Гагцхүү уурлаж түргэн түргэн эргүүлж буй хуудасны шажигнах чимээ сонсдоно.

–Баулин, танай тэнд чинь юу гээч болж байдаг газар вэ?

Баулин босоод,

-- Криворучког бид намаас хөөсөн гэж сүржин хэлэв.

–Нийтийн байр барьсангүй хэмээн Стоплер тосон авч, гэтэл энэ түүний ажил байна хэмээн хавгаст хэргийг алгадаж, –Хараагүй байна шүү дээ? Намын эсрэг хуудас гаргачихсан хойно нь сая ухаарсан байна гэв.

–Панкратов Криворучкотой холбоо сүлбээтэй талаар бидэнд баримт байхгүй.

–Энэ нөхөрт баримт байхгүй гэнэ! хэмээн Столпер ярвайж, –Панкратов шинжлэх ухаан дахь марксизмын эсрэг тэмцэж, ингэсээр байхад нь үүнийх нь дараа түүнд сонины баярын дугаар гаргахыг итгэн даалгаж, цаадах нь тэр дугаарыг нь намын эсрэг хуудас болгож байдаг байна. Панкратов Криворучког өмгөөлж байна, нөгөө декан нөхөр, хэн сэн билээ?.. гэхэд Зайцева хэргийг хэрхэн сайтар цээжилснээ харуулан,

–Янсон гэж бушуухан хэлж өгөв.

–Янсон бас Панкратовыг өмгөөлж байна. Энэ чинь нэг л зангилаа байна шүү дээ! Улс төрийн үнэлгээ нь хаана байна вэ? Яагаад чухамхүү Панкратов Криворучког өмгөөлсөн бэ?

Тайлбарлаад өгөөч.

–Панкратов үүний учир хөөгдсөн гэж Баулин ширүүлэв.

–Үгүй ээ, үүнээс болоогүй! хэмээн Столпер хашгирч –Түүнийг илт тэмцэж эхэлсэн хойно нь хөөсөн. Харин тэр нөхөр Криворучког хамгаалж байсан нь та нарт хачин санагдсангүй юу? Товчооны гишүүд шийдвэр гаргахыг санал болгож байхад, нөхөр Баулин, та тэгье гэсэнгүй. Нөхөр Лозгачёв санал болгосон байна. Гэтэл Баулин та хойш нь тавиад Панкратовг намын эсрэг хуудас гаргах бололцоо олгосон байна. Таныг харсаар байтал чинь Криворучко оюутнуудыг ялзруулж байжээ. Эсвэл та Панкратов өөрөө л тийм сонин гаргаж, өөрөө л шинжлэх ухаан дахь марксизмын эсрэг тэмцэж байсан гэж бодож байна уу? Түүний ард хэн байна? Учрыг нь олохыг бодохгүй байна! Хэнээс айгаа вэ? гэв.

–Бид хэнээс ч айдаггүй гэж Баулин Столперыг өөрийг нь хамруулан хэрцгий хариулав. Столпер ч үүнийг дор нь ойлголоо. Тэрээр Баулин руу тогтон ширтэж харснаа,

–Энэ сургууль дээр байдал ямар байгааг учрыг нь олох хэрэг гарч байна гэж санаандгүй тайван өгүүлэв.

–Тэг л дээ гэж Баулин хэлэв.

–“Тэг л дээ” гэдэг чинь юу гэсэн үг вэ? хэмээн Столпер дахин дэлбэрч, –Бид та нараас энэ талаар зөвшөөрөл гуйгаагүй байна, нөхөр Баулин. Яагаад хэргийг нь хэлэлцэж байхад Янсон ирээгүй юм бэ? гэв.

–Өвчтэй байгаа.

–Өвчтэй... Тэгвэл сургуулийн захирал хаа байна?

Баулин дал мөрөө хавчин,

–Ирсэнгүй гэв.

–Мөн ч таарсан албан газар байна даа хэмээн Столпер хямсганаж, –Та нарыг маллаад байгаа нь аргагүй юм. Бас энэ Малов гэж сайхан сэтгэлтэй нөхөр магтсан тодорхойлолт цацалж байдаг байна. Панкратовг яагаад тодорхойлолт хэрэгтэй болсныг Малов, чи мэдсэн үү? гэж асуув.

Хослол костюмтай өндөр ханхар боловч бөгтөр, бөхөрхүү Малов суудлаасаа босов. Мань хүн бараг зэрэгцээ сууж байсныг Саша сая л анзаарав.

–Мэдсэн.

–Юунаас болж хөөгдсөнөө чамд ярьсан уу?

–Ярьсан.

–Яг энд сонссон шиг чинь ярьж өгсөн үү?

–Яг тэгсэн.

–Ингэчихээд байхад нь чи тодорхойлолт хийж өгөө юү?

–Ингэчихээд байхад нь л хийж өгсөн.

–Нөхөр Малов, үүнийг чинь яаж ойлговол зохих вэ?

–Би дөрвөн жилийн өмнө юу болсныг л бичсэн юм.

–Энэ нөхөр тэр үед намыг мэхэлж байсан уу?

–Энэ тэгэхэд намыг мэхэлж байгаагүй, мань хүн тэр үед будаг үүрч зөөж байсан юм.

–Юун будаг?

–Яагаав энэ гээд Малов ширээ рүү зааж –Танай наад цэмбийг буддаг будаг хэмээв.

–“Танай” гэдэг чинь юу гэсэн үг вэ? гээд Столпер минчийгээд ирэв.

–Танай ширээн дээр байгааг хэлж байна.

–Тэгэхээр яана гэсэн үг вэ?

–Комсомолын гишүүн жирийн нэг хөвгүүн ажил хийж, үйлдвэр барилцаж байсан. Би юу гэж бичих ёстой вэ? Байсан юм байснаараа л шүү дээ.

–Байсан юм нь одоо өөр болчихоод байна хэмээн Столпер өршөөж ивээх мэт өгүүлээд, – Хэрвээ Панкратов гагцхүү чамаас гуйсан бол нэг хэрэг, харин хүн Ардын комиссарын газраар гүйж, төрөл садангийн холбоогоо ашиглаж байгаа бол шал өөр хэрэг. Нөхөр Малов, таны бодолцоогүй юм чинь энэ байна гэв.

–Бодолцоогүй байж ч мэднэ, гэхдээ би үүнийг ажил дээр нь харсан хүн. Тийм болохоор энэ хүн намын дайсан гэдэгт итгэхэд бэрх байна гэж Малов зөрсөн чигээрээ зөрөв.

–Энэ байтугай хүмүүс намын дайснууд болж байсан түүхтэй. Панкратовын юу ярихыг сонсьё гэж Столпер хэллээ.

Саша босов. Хөөгдөнө гэдэг нь тодорхой байна. Энд яригдаж байгаа юмнууд ямар ч утга учиргүй байвч хэрэг явдал цаашлах тусам шинэ шинэ ял зэмлэл тохогдоод мань хүн энэ лайтай нүхнээс яагаад ч гарч чадахгүй нь. Тэрээр энэ хүмүүсийн ойлголтыг өөрчлөн үнэмшүүлж чадашгүй. Болхи шоглол шүлэг, Азизянтай холбогдсон явдал, Криворучко энэ тэр бол хөдөлшгүй баримтууд. Давагдашгүй хүч түрж байна. Гэлээ ч гэсэн өөрийгөө хамгаалах хэрэгтэй.

–Криворучкогийн тухайд гэвэл би хүрзний тухай асуудлыг товчоон дээр ярьсан гэж Саша хэлэв.

–Юун хүрз вэ? гэж Столпер үгийг нь тасдлаа.

–Барилга дээр хүрз... агуулахын нярав байгаагүй.

–Та битгий мунхруулаад бай! Ямар учраас Криворучког хаацайлснаа шууд хэл гэж Столпер уурсан агсрав.

–Би түүнийг хаацайлаагүй. Үнэхээр барилгын материал байгаагүй гэдгийг л хэлсэн.

–Тэгвэл хүрз төдийгүй бас материал байгаагүй байх нь. Тэгээд л хэлбэл болоо биш үү гэж Столпер хямсайд хэлснээ –За яахав, ярь ярь хэмээн залхсан байртай өгүүлэх нь ингэж булзааруулаад байгаа нөхөрт асуулт тавиад ямар ч ашиггүй гэдгийг цохож байгаа нь тэр ажээ.

–Би Криворучког танихгүй, амьдралдаа түүнтэй нэг ч удаа үг сольж яваагүй.

Столпер толгой сэгсрэн, тагнай ташиж шогширсон боловч юм хэлсэнгүй.

–Тоо бүртгэлийн багшийн тухайд гэвэл тэр нөхөр хичээл заах гэж оронцоглож байсан юм.

–Марксизм- оронцог уу? гээд Столпер Саша руу эгцлэн ширтэв.

–Үгүй ээ, гэхдээ...

–За гүйцье, Панкратов, ингээд болоо! гээд Столпер босож, шувтан хатангир цээжтэй хүнд цэргийн хувцас өмсгөсөн мэт өөрт нь огт таараагүй цэрэг цамцаа доош нь дарж янзлаад, – Бид таныг сонслоо. Та намын өмнө буруугаа хүлээхийг хүсэхгүй байна, энд хүртэл биднийг мэхлэх гэж оролдлоо. Та явж болно! гэв.

Шинэ жилийг Нина Ивановнагийн дунд угтав. Варя хаа сурсан юм бүү мэд хөөрхий, ямарч атугай түүний байцаатай жигнэсэн галууны мах найрын ширээний гол чимэг болжээ. Шөнө хотын унаа явахгүй учраас өглөө болтол эндээ наргих ёстой. Тэгээд өглөө нь шууд ажил руугаа явна, нэгдүгээр сарын нэгэн ажлын өдөр.

Цорын ганц олбогт сандал дээр Вадимын дүү Вика Марасевич хөлөө ачаад тамхи сорсон шиг сууж байна. Бүх хүн ажил явдалтай байхад “би юу хийх вэ?” гэхээс өөр юу ч мэддэггүй охидын нэг, бүдүүн лазан энэ охин цайвар хонгор үстэй ихэмсэг зантай эмэгчин болон хувирчээ. Ийм хүүхнүүдтэй хагас сайны орой “Метропольд”, ням гарагийн өдөр “Националь” ресторанд тааралдаж болно. Тэрээр яг шинэ жилийн өмнөхөн хонгортойгоо муудалцсаны учраас энд ирж, тэгээд ч байдлаа хүнд ойлгуулах гэж гуньсан царайлж суугаа нь энэ ажээ.

Юра Шарок түүнийг хөгжөөх гэж оролдон ая тал засаж эхлэв. Энэ нь Ленатай ямар харьцаатайгаа нуух гэсэн ч юм шиг. Харин ингэж байгааг нь хөндлөнгөөс харахад тун хачирхалтай. Тэр хоёрын харьцаа Вадим Марасевичээс бусад хэнд ч гэсэн нууц зүйл байхаа аль хэдийн больсон билээ. Вадим өөрөө хүүхэн үзээгүй болохоор тийм харьцаанд орсон хүн тэс өөр болдог гэж бүрэн итгэх тул Лена, Шарок хоёрын тухай ямар ч сэжиг байсангүй. Тэрээр Ленагаас тийм өөрчлөлт олж үзээгүй байгаа ажээ.

Вадим Москвагийн уран сайхны академик театрт “Амьгүй албатыг” найруулж тавьснаас эхлээд Димитровыг зөвтгөж Рувельгийн “шинэ чиг бодлого”, Ментонд Луначарский нас барсан энэ тэр лүү үсчин есөн жорын юм бурна. Тэрээр хэн бүхэнд мэдээжийн юмыг хүртэл гагцхүү өөрөө л цаад нарийн учрыг нь мэдэж байгаа хүний дүртэй ярьж чадна.

Юра Шарок ийшээ ирэхийнхээ өмнө эцэгтэйгээ балгасан тул яггүй хөгжүүн нүүрэмгий байв. Викаг эргүүлж байгаа нь эд нарын дургүйг хүргэж байна уу? Ёстой болох нь тэр! Тэгэх тусам нь эргүүлнэ дээ.

Варя галуугаа Нинад найдаж орхиж чадалгүй тийнхүү галуугаар шалтаглан гэртээ байгаа ажээ. Үнэн хэрэгтээ бол сургуулийн хүүхдүүдийн дунд байснаас томчуудын дунд байх нь илүү сонин байжээ. Түүнээс гадна Максим румба бүжиглэдэг нэг найзтай ирнэ гэж хэлсэн юм байж. Серафим гэдэг хачин нэртэй энэ залуухан сонсогч одоо эгшигт хайрцгийн бариулыг хичээнгүйлэн эргүүлж сууна.

Серафимийн хажууд Макс гуниглан зогсоно. Тэрээр Нинад хамаг сэтгэлээ илчилсэн боловч цаадах нь тас эсэргүүцээд өчүүхэн төдий ч горьдлого үлдээсэнгүй. Түүнээс гадна Сашаг хайрлаж хүндэтгэн биширдэг учраас тэрний хэрэг явдлаас болж бас гутарчээ.

Сашагийн сэтгэл санаа ямар байлаа гэсэн тэрээр хуучин яаж аж төрж байсан яг л тэгж аж төрөх ёстой учир ийшээ ирэхгүй байж чадсангүй. Шинэ жилийг мань хүн шинэ жил шиг л угтана.

Ийнхүү цөмөөр цагаан бүтээлэгтэй ширээний ард сууцгааж байна. Ширээний дээд талд

Нина, баруун гар талд нь Максим, Саша, Варя, Серафим дөрөв, зүүн гар талд нь Вадим, Лена, Юра, Вика дөрөв тус тус суужээ. Бүх юм гялалзаж гялтганан, юм болгон байр байрандаа тавиастай, идэх юмны сайхан үнэр ханхлан хорхой хүргэж, сэтгэл гижигдэнэ. Гадаа жавартай шөнө байвч байшин дотор дулаахан сайхан, бүсгүйчүүд ганган торгомсог оймстой өндөр өсгийттэй байцгаана. Гараг эрхэс тавилант замаараа орчиж, сансар хорвоо мөнх хөдөлгөөнөө давган, манай энэ хэд Христосын мэндэлсний нэг мянга есөн зуун гучин дөрвөн онтой золгож байна. Ширээн дээр архи, улаан, цагаан дарс бас гичний шүүстэй май загас, валютийн дэлгүүрээс авсан гахайн утмал мах байна. Нэг мянга есөн зуун гучин гурван онтой эд нар ингэж золгосон, гучин тав, гучин зургаа, гучин долоо гээд бусад олон онтой ингэж золгоно. Эд нар залуу учраас үхэх, өглөхийн алиныг ч эс төсөөлнө, эд нар үхэх өглөхийн төлөө төрөөгүй амьдрах, залуурхах, аз жаргал эдлэхийн төлөө төрсөөн.

–Хуучин оноо үдэцгээе, энэ он бол бидний амьдралын нэгэн он байлаа гэж Вадим өгүүлээд – одессийнхний ярьдгаар бидний замд хэн ч сарнай цэцэг дэвсэж өгөөгүй. Гэвч сарнайд хучигдсан зам бол амьдралын зам биш. Жинхэнэ амьдралын зам өргөсөөр хучигдсан байх болой... гэв.

Цагийн харанга дүнгэнэхүйд бүгд сандлаа түжигнүүлэн босож хундгаа өргөлөө.

–Шинэ жилийн мэнд, шинэ аз жаргалын баяр, ура! хэмээн Вадим дуу хадаав.

Хундага харшин жингэнэлдэж, тавагтай зуушнууд гар дамжин ширээ тойрлоо. Макс галууг тун чадамгай эвдэв.

–Мастер! гэж Саша хэлэв.

–Галуу нь л байдаг юм бол... гээд Юра тавгаа тослоо.

–Максим, надад хөл өгөөрэй гэж өдий хүртэл чимээгүй байсан Вика дуу өгөв.

–Нөгөө хөлийг нь надад! –Вадим хоолонд сайн билээ.

–Марасевичийнхэн хамаг юм хамчих нь!

–Марасевичийнхнийг болиулаарай!

Вадим хутгаараа таваг тоншлов...

–Улаан Армийн найдвар Максын төлөө хундага өргөө!

–Макс! Максимушко! Хонгор минь, битгий мартаарай!

–Нөхдүүд ээ, миний сэрээг дэлсчихэж!

Вадим дахиад л хутгаараа таваг тоншлов.

–Манай цорын ганц зочин, бас Улаан Армийн найдвар Серафимийн төлөө ууцгаая.

-- За залуу минь, таны эрүүл мэндийн төлөө!

-- Залуу нас бол гэм биш маш булай явдал.

Серафим нүүр нь улайж босоод энэ шуугиантай улсаас эмээн дэмий л мэхийв.

Вадим манай хөөрхөн хүүхэн Ленагийн төлөө, бас түүнд мөчөөгөө өгөхгүй Викагийн төлөө хундага өргөө гэв. Вадим гэж хэл ам нь загатнасан юм шиг амьтан хүнийг ч яариулахгүй санаатай.

–Сургуулийнхаа төлөө ууцгаая! гэж Максим санал гаргав.

–Уяхан сэтгэлт тугалмай, уухайс! гэж Юра өгүүлэхэд Макс түүн рүү хялайж хараад,

–Сургуулиасаа няцаад, бүх юмаа сэгсрээд хаячих уу? гэв.

–Би Максын хундагыг дэмжиж байна хэмээн Вадим ярианд оролцож –Төрсөн гэр, төрөлх сургуулиа мартаж болохгүй шүү гэв.

–Сургуулийн төлөө, хөдөлмөрийн нэгдмэл сургуулийн төлөө! гэж Юра егөөдөв.

Муусайн нуснууд! Шүлхийнүүд! Та нар тэгж л бай! Сургуулийнхаа төлөө ууя гэж байгаа бол уугаад л өгье л дөө. Юуны төлөө уух нь надад ямар хамаа байх вэ дээ гэж Юра бодов.

–Юра, биднийг нэг их гялайлгалаа гэж бүү бод гэж Юрагийн бодлыг мэдсэн Нина хэлэв. Тэрээр Викаг эргүүлээд байгаа Юрад дургүй нь хүрнэ. Нина тэр хүүхнийг хэзээнээс үзэж чаддаггүйг хэлэх үү, түүнийг урьсан залсан хүн ч байхгүй, бас хажууд нь Шарок Ленаг гомдоогоод байгаад зэвүү нь хүрнэ.

Вадим аюултай донсолгооноос тойрчихлоо.

–Ирээдүйн прокурор Юрий Шарокийн төлөө!

–Шоронд хийчихвэл туслаарай гэж Макс гэмгүй өгүүлэв.

–За одоо гэснээ Вадим амаа арчаад –гэрийн эзэгтэйн төлөө, манайхны зүрх, сэтгэл, тархи болсон Нинагийн төлөө! гэж хундага өргөв!

–Ниночка! Нина!

–Тэгж яривал ч хоёр эзэгтэйн хоёулангийнх нь төлөө гээд Саша Варя руу эргэж харав.

Эдний дотор насаар хамгийн бага нарийхан цэмцгэр Варя ямар нэгэн юм буруу хэлчихээс болгоомжлон чимээгүй сууна. Серафим түүнтэй яриа үүсгэх гэж хулчгархан оролдсоор. Ийнхүү ичингүйрэн байгаа нь Сашад сонин санагдсан тул тэрээр Серафимийг ярианд татаж оролцуулах санаатай өөрөө Варятай яриа өджээ. Варя ч уриалгахан хариулж эргэж харахад нь энхрий царай, бөлцгөрдүү давхраатай нүдийг нь Саша тун ойрхноос харлаа.

Ширээ сандлаа зайчлаад цөмөөрөө бүжиглэж эхлэв. Эгшигт хайрцаг “Энэ л хархан нүд намайг олзоллоо, эргээд би мартаж чадахгүй байнам” хэмээн аялна. Юра Викатай, Вадим Ленатай, Варя Серафимтай бүжиглэв. Дараа нь Макс, Нина хоёр тэдэнтэй нийллээ.

Пянз солих үед Саша,

–Ах дүү нар минь намайг бас бүжиглүүлээч дээ гэв.

Тэрээр Варяг аваад уяхан бие, хөнгөхөн гишгээ, баярласан сэтгэлийг нь мэдрэн мэдрэн бүжиглэв. Тэгэхүйд Нинагийн дургүйг хүргэдэг Варягийн нөгөө оо энгэсэг, сүрчиг ус, хашаа хороо, хүүхэд бандийн явдлууд бол амьдралын амтыг амсаж, энэ л нялх ариун сайхан ертөнцтэй дөнгөж золгож байгаа бяцхан хүүхний өчүүхэн зүйл байсныг мань эр ойлголоо. Одоо чухамхүү ийм ертөнцөөс өөрийг нь хүчээр салгаж байгаа билээ.

Хэрүүл санамсаргүй үүсэв. Юра, Вика хоёр хонгил руу гарснаас Нинагийн уур дэлбэрчихэв.

–Шуугиж болохгүй гэж би гуйсан шүү дээ. Би чинь хөршүүдтэй хүн. Гэтэл заавал зөрнө гэнэ! Энд ямар зай мундсан биш, заавал хонгилд холхилдохын хэрэг юу байна гэж Нина уурлаж улалзав.

–Боль, боль, юу ч болоогүй л байна шүү дээ хэмээн Лена инээмсэглэв. Юра тэртэй тэргүй түүнийг доромжлоод байсныг Нина улам илчилсэн учир Ленад эвгүй байсан хэрэг.

–Биеэ барь гэж Макс цайлган сэтгэлээр зөвлөв.

–Ичих нүүрэндээ илэг наачихжээ. Эд нар яваад өгнө, гэтэл би чинь энэ улстай хамт амьдарна гэж Нина узалзсан чигээрээ зөрөв.

–Болиоч гэж Саша хэлэв. Тэрээр Юра, Вика хоёрын аль алинд бас дургүй нь хүрч байвч хэрүүл шуугиангүй байлгахыг боджээ.

Вадим тоглоом болгож өнгөрөөх санаатай,

–Миний дүү бие засах газрыг барагтай бол олдоггүй юм гэж хэлж үзэв.

Хэрсүү зантай Нина ингэж дүрсхийн уурладгийг бүгдээрээ мэднэ. Энэ уур нь яг эхэлсэн шигээ дорхоо гарчихна. Шинэ жилийн шөнө бүгдээрээ дор бүрдээ ядарч, унтахын түүс болоод ялимгүй юмнаас уцаарлаад эхэлдэг нэгэн мөч байдаг бөгөөд тэр нь болчихжээ.

Юра Ленатай зэрэгцэн сууж гараа мөрөн дээгүүр нь тавиад,

–Гэртээ зөнөсөн эмийн голын хий дахиад хөдөлчихөж гэж зэвүүрхэн хэлэв.

Энэ бол санаандгүй хэлсэн үг биш. Тэр хоёрын харьцаа бол гагцхүү тэр хоёрт хамаарах зүйл гэдгийг зориуд харуулах гэсэн мэт Ленагийн мөрөн дээр гараа тавьж байгаад бодолтой тайван хэлсэн үг.

–Шарок, хэлээ тат! гээд Саша түүн рүү хөмсөг зангидан харав. Одоо түүнтэй тооцоо хийх шалтаг олдох нь энэ. Юрагийн эх л нэг их сонин юм ярьдаг хүн болох гэж Сашагийн ээжид түүний сургуулиас хөөгдсөн тухай хэлсэн хэрэг. Энэ нь Юрагийн муу санаж явдгийнх гэдгийг Саша ойлгосон ажээ.

–Цөмөөрөө ууцгаая... хэмээн Вадим тал засах мэт эхэлтэл Саша түрүүчийнхийгээ үргэлжлүүлж,

–Чамайг ийм хүн гэдгийг би аль хэзээний мэднэ.

Нөгөө нээлтээрээ бас бусад хүнийг баярлуулах гэж байна уу? гэв.

Юра цайгаад явчихав.

–Чи юу мэдээ вэ? Юу вэ хэл л дээ!

–Хэлдэг газар нь ч биш, цаг нь ч биш, бас тэгээд хэн болгонд сонин биш.

–Яагаад газар, цагийг чи тогтоож байгаа юм бэ? Яахаараа чи тулгах ёстой юм бэ? Чи өөрийгөө өргөмжилж байна. Тэгээд юунд хүрсэнээ харахгүй юу.

–Дуугаа тат! гэж Макс хэлэв.

–Цохидоггүй газар цохилоо! гэж Вадим бувтнав.

–Энэ бол зөвхөн миний хэрэг, чамд, танайханд ямар ч падгүй хэмээн Саша тайван өгүүлээд – Чамайг юу бодож явдгийг сонсох уу? Чи бол хар амиа бодож, гон бие гозон толгойгоо хоохойлсон өчүүхэн амьтан, үүгээр манай тал яриагаа дуусгалаа гэв.

–Тэгвэл чи нүцгэн ноён, цэрэггүй генерал. Үүгээр мана тал бас яриагаа дуусгалаа гэж Юра хариулснаа суудлаасаа босон – Лена, явья! гэлээ.

–Лена! хэмээн Саша бүсгүйг дуудав.

–Юу гэв? гээд Лена эргэн харж нөхөрсөг инээмсэглэн саяын зөрчлийг зөөллөхийг оролдов.

–Чи энэ өөдгүй амьтнаас дээр юм олсонгүй гэж үү?

Лена час улайгаад өрөөнөөс гүйж гарав. Юра үүдэнд зогсхийн Саша руу нэг харснаа хүүхний араас гарлаа.

–Чи Юраг дэмий тэгж хэллээ гэж Макс муу бодолгүй өгүүлэв.

–Хүний шааранд дургүй гэж Саша барайж хэллээ.

Гэтэл улам гунигтай болов. Биеэ барьж чадалгүй шинэ жилийн наргианыг баллачихлаа.

Ээж нь уйлаад байдагсан бол дээр байхсан. Гэтэл таг чиг дуугаа хураачихаад яасан ийснийг нь ч асуудаггүй. Саша сүйрсэн байна, энэ л гол зүйл.

Ээжийнх нь гөлөрсөн харц Сашагийн зүрхийг маажилж байх шиг болно. Үдэш орой ном уншивч үг үсгийг нь үзэж харж байгаа юм байхгүй, зүгээр л хуудсыг нь эргүүлэхээс цаашгүй. Өдөр шөнөгүй ганцхан юм бодно. Сашагийн дэргэд эр хүн алга, өөрөө гэр бүлээ бүрэн бүтэн байлгаж чадсангүй, энэ золгүй амьдрал нь л хүүхдийн сэтгэлийг хар багаас нь сэвтээсэн гэж гаслан бодлогоширно.

Павел Николаевич ажлын зав гармагц сар хагас хэртэйн дараа ирнэ гэж мэдэгджээ. Софья Александровна нөхрөө мэдэлгүй яахав дээ, цаадах нь энэ сар хагасын хугацаанд Сашагийн явдал түүний оролцоогүйгээр учир нь олдчихно гэж тооцоолсон хэрэг. “Марк үнэхээр юу ч хийж чадахгүй гэж үү дээ?” гэж асуусан байсан. Тэднийхнийг дандаа өөлж зэмлэж байдаг нь тэр зэрэг! Тэрээр Маркад захиа бичээд их хуралд мөд очно, тэгэхдээ бүгдийг зохицуулахаар найдаж байна гэсэн хариу авсан. Саша урьдын адил өмгөөл ивээлгүй байгаа болохоор тэр хоёроос захидал аваад ээж нь тайвширч чадсангүй.

Софья Александровна гэрээсээ зөндөө удаан гараад явчихдаг боллоо. Намхан пагдгар буурал ээж нь хашаан дотуур яаж орь ганцаараа явж байгааг Саша харуулдан зогсоно. Тэрээр үдийн хоолоо өөрөө халааж иднэ, заримдаа халаах ч юм байхгүй байх нь бий. Ээж нь хашаа алга болоод байдаг хэрэг вэ? Эгч дүү нар руу нь утасдахад тэднийхнээр огт үзэгдээгүй гэнэ. Албан газруудаар өөрийнх нь тухай хөөцөлдөн нөлөө бүхий танилуудаа хайж явдаг юм болов уу? Гэвч тийм танил гэж байхгүй, түүний бүх танилыг мань хүн толгой дараалан мэднэ.

–Та хаачив аа, хаагуур алга болчихдог юм бэ?

Ээж нь эсвэл дуугарахгүй, эсвэл хашаа ч очоогүй, Арбатаар л явж байгаад ирлээ, хашаан дотор жаахан суулаа гэсхийгээд өнгөрнө.

Саша ч гэсэн хүүхэд ахуй цагаас танил болсон Арбатын хөндлөн гулд гудмаар, олон баганатай товгор хээтэй, хурц ногоон дээвэртэй, цэвэрхэн шавардсан цагаан нүүртэй хуучин өргөө орднуудын хажуугаар хэсүүчлэн явна. Кривоарбатын гудамд дунд сургуулийн талбайн байран дээр одоо уран барилгач Мельников нэг байшин барьчихжээ. Хачин дугариг барилга, Сургуулийн газар давхрын эрээн даавуун хөшигтэй цонхнууд хуучин янзаараа гэрэлтэж байх нь энд үйлчилгээний ажилчид мөн урьдын адил аж төрж байгаа ажээ.

Саша бүлгийн ахлагч болж Рублевод пионерийн зусланд очсоноо санав. “Амралтын зуслан Рублево руу бид явж байна, аль хэдийн бүх юм бэлэн болсон байна, эд хогшил хэзээний тэнд байгаа, эзэн бид нар л алга байгаа...” Тэр үед мань эр хатуу гараар сахилга журмыг сахиулж пионерүүдийг айлгадаг байсан боловч ганцхан сургуулийн мужааны хүү Костя Шабрин гэдэг дүрсгүй, үг дуулдаггүй нэг жаалын аяыг олж чадаагүй. Бас нэг хэрэг тарьсных нь дараа Саша түүнийг гэрт нь буцаахаар шийджээ.

Тэгэхэд тогооч авгай,

–Саша, цаадхыгаа битгий буцаа, эцэг нь алчихна гэж хэлсэн.

Алчихна гэдэг чинь юу гэсэн үг вэ? Хэнд ч хүн алах эрх байхгүй. Костяг үлдээхийг хүүхдүүд гуйж, Саша ч өөрөө түүнийг өрөвдөж байсан боловч шийдвэрээ өөрчилбөл өөрийнхөө нэр хүндийг унгасан болчих гээд байжээ.

Тэд ч зуслангаас ирж, хичээл ч эхэлжээ. Костягийн эцэг Сашад юу ч хэлээгүй, харин нэг удаа сургуулийн хонгилд тааралдахдаа зогтусан удаан гэгч нь түүнийг ширтэн харжээ. Саша энэ харцыг үүрд тогтоож авсан. Тэр үед Саша ямар хэрцгий тэнэг загнаа вэ? Хамт олны сонирхлын үүднээс сахилгыг чанд сахиулах шаардлагатай хэмээн тэрээр бяцхан Костяг золионд гаргачихсан билээ. Ийм шийтгэл Костяд өөрт нь ч сургамж болно гэж тэр үед бодсон. Харин Костя эцгийнхээ өмнө ямаршуухан байх тухай бодсон бил үү?

Тэрээр Плотников хөндлөн гудмаас эхлээд Могильцев руу, дараа нь Мертвый руу эргэнэ. Энд Данийн элчин сайдын яамны эсрэг талд буй нэг харшид тухайн үедээ Хамовникийн районы комсомолын хороо байсан бөгөөд тэнд найман жилийн өмнө түүнийг комсомолд элсүүлсэн билээ. Тэгэхэд мань эр савхин цамц өмсдөг хийтэй хээнцэр залуусыг үзэн яддаг, номноос өөр хайрлаж эрхэмлэх юм байдаггүй хөвгүүн байжээ. Номоо ч гэсэн уншсаныхаа дараа номын санд бэлэглэчихнэ, тэр ч байтугай сургуулийн коммуна байгуулах гэж оролдсон удаатай, толгойд юу хамаагүй орж ирдэг байж дээ, тэр үед.

Энэ бүх явдал яагаад чухам түүнд тохиолдов? Тэрээр олонхийн саналыг итгэн дагах ёстой бус уу? Гэвч Баулин, Лозгачёв, Столпер гурав олонхи хараахан биш. Сталинд бичих үү? Сталин улс оронд мэдэмхий хүн хэрэггүй, мэргэжилтэн хэрэгтэй гэдгийг ойлгож байгаа, тэрээр бас хоосон чалчигчийг үзэж чадаггүй, гэтэл Азизян бол хоосон чалчигч, Сталин албан тушаал хөөцөлдөгчид дургүй, гэтэл Лозгачёв бол албан тушаал хөөцөлдөгч, дүвчигнэгчийг үзэн яддаг, гэтэл Баулин бол дүвчигнэгч. Сталин алиа хошины нарийн ухаантай юм чинь гэм хоргүй шоглол шүлгийг зөвөөр үнэлж үзэхсэн. Гэвч хувийн хэргээр Сталинд хандана гэдэг бол даруу бус явдал.

Саша нэг удаа харьж явахдаа ээжийгээ харав. Ээж нь хэн нэгэн хүнийг нүдээрээ хайн хашааны хаалганы тэнд зогсож байжээ.

Хоёулаа орцны үүдэнд хамт ирснээ,

–Чи ор, би дахиад жаахан явмаар байна гэж ээж нь хэлэв.

–Даарчихна шүү дээ.

–Би дахиад жаахан явна аа гэж ээж нь давтан өгүүлэхэд царайд нь зөрүүд туулайн төрх илрэв. Ийм төрх хуучин бол эцэгтэй нь шинэ хэрүүл шуугиан дэгдээхийн дохио байдагсан.

Саша дараа нь нэг удаа ээжийгээ Арбатад явж байхыг үзэв. Тэрээр байшингийнхаа үүдний түүгээр зугуухан өнгөрч, цаг засварын газрын дэргэд очиж шилний цаана тавилсан цагнуудыг харж байгаа дүртэй зогссоноо, буцаж гудамжны нөгөө тал руу ширтэн явсаар эмийн сан хүрээд дахиад эргэв. Эцгийг нь хөрш хүүхэн Милица Петровнатай уулзаад байна гэж

бодохоороо түүнийг мөшгиж мөрддөг байх шиг. Гэтэл эцэг нь байхгүй, зохиомол нууц амраг хүүхэн ч байхгүй, хардам сэрдэм юм гэж байхаа больсон атал ээжийнх нь толгойд дахиад л нэг салж тонилохгүй санаа орж ирсэн бололтой, ганцхан чигт мэрийхээрээ мэрийчихсэн харж байна.

Тэгснээ айсуй яваа машинуудыг үзэхээс айхдаа ийш тийшээ харахгүй хуучин янзаараа толгойгоо духайлган тонгойсоор гудамж хөндлөн гарав. Жолооч нар гэнэт тооромсоглон, кабинаасаа цээжээ гарган хараал зүхэл тавивч ээж нь юун ийшээ тийшээ харах мантай, тонгойсон чигээрээ авралын явган зам руу зүтгүүлнэ.

–Хэнийг хайгаад байгаа юм бэ? гэж Саша ээжээсээ асуув.

Тэрээр хүүгийнхээ үнэмшихгүй юмыг хэлэхээсээ айж мэгдэн сандарлаа.

–Надаас юу нуугаад байна вэ?

Ээж нь айсан нүдээ бүлтийлгэн харж,

–Чамайг мөрдөөд байна гэв.

Хүү гайхшран,

–Хэн намайг мөрдөө вэ? гэж асуув.

–Нэг нь чихий нь буулгасан малгайтай, нөгөө нь даавуун пальтотой жижигхэн, гурав дахь нь тоногтой эсгий гуталтай өндөр, муухай ааштай ийм гурван хүн бий, тэд нар ээлжээр мөрдөж байгаа.

–Зүйтэй! Цөмөөрөө хамт явах хэрэг юу билээ? гээд Саша инээд алдав.

–Би аль алиныг нь зүсээр нь мэднэ, бас дуугаар нь юм уу араас нь таньж чадна. Би талхны мухлагт зогсож байсан чинь нөгөө эсгий гуталт нь ирээд ард зогслоо, би эргэж хараагүй, гэлээ ч гэсэн яг тэр этгээд зогсож байгааг мэдэж байсан. Би талхаа аваад хажуу тийш болсон чинь тэр талх аваагүй хэрнээ бас л хажуу тийш болоод нөгөөдөхдөө намайг үзүүлэх гэж миний ард зогсчихсон, тэд нарын арга нь тийм юм. Би тэд нарыг мэдчихсэнийг гадарлачихаад намайг ийш тийшээ харангуут Никольский руу орж алга болчихоод, дараа нь Денежныйгээс гараад ирдэг юм. Би тэгэхлээр нь шууд Денежный рүү очоод яг түүнтэй тааралдчихад мань хүн буцаад явчихна, тэр яг мөн гэдгийг би мэднэ.

–Тэд нар чинь хэнийг мөрддөг юм бэ, намайг уу, таныг уу? гэж Саша инээмсэглэн асуув.

–Тэд нар манай байшинг харуулдаад байгаа юм. Манайд хэн ирж, хэн гарч байгаа, чиний хэзээ гарч, хэнтэй цуг явж, хэнтэй ярилцаж байгааг мөрддөг юм. Би махны дэлгүүрт загасныхаа тасалбарыг тасалж байтал нөгөөдөх чинь ард зогсчихоод “Дөрөв дэх тасалбар хэрэгтэй” гэж байна. Эргээд хартал тэр бас цаашаа харчихсан, би даавуун пальтогоор нь таньсан л даа.

–Дөрөв дэх нь хэрэгтэй гэж яг хэллээ гэж үү дээ? хэмээн Саша бүр инээдэм болов.

Ээж нь ярьж байгаа үгийнхээ аясаар толгой дохино.

–Смоленскийн тэндэх харуулын цагдаа бас тэдэнтэй нэгсэж байна. Би нэг удаа нөгөө өндрийн араас явж байтал тэр нэг хүн рүү дохиод цагдаа руу ирмэсэн, цаадах нь түүн дээр очиж үнэмлэх бичгээ шалгуул гэсэн. Өндөр өөрөө буцаж эргэтэл намайг үзчихээд их муухай харсан, тэгээд хоёр өдөр үзэгдээгүй, гэтэл дарга нараасаа хатуухан хишиг хүртсэн гэж нөгөө жижиг нь хэлсэн.

–Хэнд хэлсэн гэж?

–Надад. Тэр миний ард зогсож байхдаа ганцхан надад дуудахаар хэлдэг юм. Тэгээд би эргэж харах юм бол тэр цаашаа харчихна. Би түүнийг эвгүй байдалд оруулахгүйн тулд эргэж харахаа больсон, тэр чинь мэдээж надтай ярилцах эрхгүй шүү дээ. Би дууг нь сайн мэднэ.

Саша ээж рүүгээ айх гайхах зэрэгцэн харав. Тэдний амьдралд нэгэн аймаар юм шургалан орж байх нь. Тэрээр энэ өрөөнд өсөж бойжсон, энд байгаа юм болгон түүний амьдралын нэгэн тасархай, энэ бүхэн байсан янзаараа байр байрандаа байх болно, гагцхүү эзэнгүй л байх болох нь ээ. Тэрээр ёроол руугаа чангаагаад байгаа усны эргүүлэгт орчихжээ. Мань эр энэ мөчид өөрийнх нь хувьд өөрийнх нь хамгийн эрхэм, номхон дөлгөөн хүн болох ээжийг нь л энэ усны эргүүлэг битгий татаад авчихаасай гэж бодно.

–Нэг удаа нөгөө жижиг миний ард зогсож байгааг мэдээд эргэж харалгүй “Та нар Сашаг аваад явчихгүй биз дээ” гэж асуулаа. Тэд дуугарсангүй, ямар ч хариу алга. Би тэсэлгүй эргээд харчихсан чинь мань хүн хуруугаа уруулдаа хүргэж дохиод, надаас ухран бөөн улсын дунд ороод алга болчих нь тэр.

–Энэ бүхэн цөм таны зохиосон үзэгдэл гэж Саша өгүүлээд –Намайг ч, таныг ч мөрдсөн хүн ердөө байхгүй, та бид хоёр хэнд ч хэрэггүй, ямар ч төрийн гэмт хэрэгтнүүд биш! Инээдтэй юм! Хэрвээ намайг аваад явах байсан бол тэгж шал дэмий мөрдөж цаг алдалгүй аль хэзээний аваад явчих шүү дээ. Түүнээс гадна намайг сургуульд маань буцааж авна гэдгийг мэдэж байгаарай. Гэхдээ одоо хүн амьтан их хурал гээд надтай мантай байгаа, их хурлын дараа учрыг нь олно. Үүнээс бусад элдэв юмыг толгойноосоо гаргаж хая. Амьдралаа бүү хордуул гэв.

Ээж нь бөгтийн ганцхан зүгт харж, татав туссан мэт үг дуугүй толгой сэгсэрнэ. Саша юу ч ярьж, яаж ч үнэмшүүлэх гэж оролдсон, ээж нь бүх юм яг тийм байгаа, өөрөө гарцаагүй мэдэж байгаа гэж зүтгээд болдоггүй. Өчигдөр ч тийм байсан, өнөөдөр ч тийм байгаа, маргааш ч тийм л байх болно. Мань хүн маргааш гадагшаа гарлаа гэхэд нөгөө гурвын нэгийг заавал харна, хэрвээ нөгөө жижиг жижүүрлэж байвал тэр өөрт нь нэг юм хэлнэ, магадгүй Сашаг авч явах уу, үгүй юү гэдгийн талаар ч хариу өгч мэднэ.

Нөгөө даавуун пальтотой жижигхэн хүн Софья Александровнагийн асуултад бас л хариулсангүй, харин өрөвдсөн янзтай харчихаад бушуухан хараа буруулжээ. Одоо ингээд хөөрхий эх муу юм хүлээж эхлэх нь тэр. Чимээ дохио болгоноос айж, хэрвээ чимээгүй бол

аймшигт автана. Тэрээр шагаар яваа хүний хөлийн чимээ чагнан хэдэн цагаар ч хамаагүй үүдэндээ зогсох буюу цонхны тавиур дээр гараад хашаан дотуур хэн явж байгааг ажигладаг болжээ. Нэг удаа цагдаа харчихаад ухаан алдталаа айж, барьсан тавьснаа мэдэхгүй дэмий л өрөөн дотуураа бэгцгэнэн холхижээ. Цагдаа тэднийхээр орсонгүйг бодоход Сашагийн тухай асуух гэж хөршүүд рүү нь орсон хэрэг. Түүний талаар муу хэлэх хүн байхгүй, гэвч хүмүүс өөрөөсөө хор хөнөөлийг зайлуулж байна гээд өөр нэгэндээ хор хүргэх нь тун амархан.

Сашагийн хэрэг явдлыг тэдний байшингийнхан толгой дараалан бүгд мэдэж байгаа, бодвол бүгдийг нь дуудаж уулзаж, бүгдээрэнгийнхээр нь ороо биз. Ээж нь хашаан дотор жижигхэн төмөр саравчтай богинохон сандал дээр суугаад дэргэдүүр нь хэн яаж өнгөрсөн, өөр рүү нь ямаршуухан байдалтай харсан, яаж мэндэлсэн энэ тэрийг цэгнэн бодно.

Байрын захиргаанаас утасдаж Сашаг ирж уулз гэжээ. Ээж нь байрын захиргаанаас байнга айж байдаг хэрнээ өөрөө уулзахаар явав. Гэтэл Сашагийн ажлын газраас гаргасан нэгэн хэвшмэл тодорхойлолтыг тодруулахыг шаарджээ. Шалтаг! Байрын захиргааны дарга Виктор Иванович Носовыг тэрээр хорин жил мэднэ, жижигхэн Витька хашаан дотуур гүйж явдагсан, бас талийгаач ээжийг нь мэднэ, тэр ч гэсэн өөрийг нь мэднэ, Сашаг ч мэднэ. Гэтэл сая дөнгөж зэрвэсхэн харснаас гадна оюутан Саша яагаад ачигч хийж байгааг асуусангүй, тэгэхлээр бүх юмыг мэдэж байгаа хэрэг. Бас баяртай гэж хайнгахан хэлсэн. Гэтэл паспортын байцаагч хүүхэн завгүй байгаа дүр гаргаад ерөөсөө дуугараагүй.

Нэг хүн утасдаж Сергей Сергеевичийг асуухад нь Софья Александровна энд тийм хүн ерөөсөө байхгүй гэж хариулжээ. Гэтэл таван минутын дараа шал өөр дуутай хүн дахиад л Сергей Сергеевичийг асуусан. Дараа нь бас дахин утасдсан боловч юу ч дуугараагүй, гэхдээ хүн амьсгалж байгаа нь мэдэгдээд байсан. Тэдний хөрш бүсгүй Галяг хэд хэдэн удаа яриулж өгөөч гэж дуудуулсан, хуучин түүнд ингэж ойр ойрхон утасдаггүйсэн. Галя нэг л битүү утгатай хоёрдмол санаатай юм хариулчихаад харилцуурыг өлгөж, газар шагайгаад бушуухан өрөө рүүгээ яваад орчихно.

Нэг үе нөхөртэйгөө харддаг байсан Милица Петровна одоо дахин сайдаж найзалдаг болсон бөгөөд тэр хүүхэн тус болохоор амлажээ. Милицад залууд нь нэр нөлөө бүхий олон хүн дурлаж байсан боловч цөмөөрөнг нь залхааж одоо нэг ч хүнгүй болсон аж. Харин сандал дээр олонтаа ханиндаа суудаг Маргарита Артёмовна гэдэг ухаантай, намбалаг, буурьтай армян авгай Саша нэг хэсэгтээ Москвагаас явчих нь зүйтэй хэмээсэн төдийгүй өөрийнхөө төрөл садангийнхан руу, Нахичеваньд очихыг санал болгожээ.

Софья Александровна энэ санааг олзуурхан авчээ. Харин өөрөө энэ тухай Сашад хэлэхээсээ айгаад Михаил Юрьевич гэдэг хөршөө гуйв. Ийм зөвлөлгөөг эрэгтэй хүн өгөх ёстой.

Михаил Юрьевич ном, сийлбэр хоёр цуглуулдаг ганц бие, сэхээтэн хүн. Альбом, хавтас энэ тэр хөглөрсөн хуучин цагийн тавилгатай өрөөнд нь ном судрын тоос, будаг, цавуу, бэхний үнэр үүрд шингэн нэвчжээ. Тэрээр олж авсан цуглуулгийнхаа юмыг Сашад л голдуу үзүүлнэ, ер нь түүнтэй ярилцах дуртай. Өнөөдөр мань хүн Доре зураг чимэглэлийг нь хийсэн Дантегийн “Тамыг” Сашад үзүүлэв. Тамын дотуур хүмүүс хуйлралдан эр, эм хүн, хүүхэд, толгой, хөл, гар, хүмүүн төрөлхтнийг түймэрдэж буй хүсэл тачааллын мөнхийн гал энэ тэр байна.

Михаил Юрьевич Дантегаас гадна “Академия” эрхэлж хэвлүүлсэн Маккиавелийн “Хааныг” олж авчээ. Саша үүнийг үзээд,

–Би энэ номыг мэднэ, засаг төрийн тухай эргэцүүлэл нь гэнэхэн, түүний мөн чанарыг шинжлэх ухааны үүднээс гаргаж огт чадаагүй гэж боддог гэхэд Михаил Юрьевич,

–Магадгүй, гэхдээ сайн явдал, муу хорын үндсийг аль ч эрин үед судлах нь ашигтай, их бага ямар ч юмны нэрээр сайн явдлын үндсийг улан дороо гишгэлэх ёсгүй. Саша, таны явдалд хөндлөнгөөс оролцож байгааг минь уучлаарай, таны паянгийн тухай ээж тань надад ярьсан юм, харин тэглээ гэж ээжийгээ битгий загнаарай. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэж мэднэ шүү дээ. Та ер нь эцэг рүүгээ юм уу, эсвэл нагац руугаа яваад өгвөл яасан юм бэ? гэж асуув.

–Яваад өгөх ий? Хэмээн Саша гайхаж –Шалтгааныг нь олж харахгүй байна. Тэр хэргийг надгүйгээр учрыг нь олж болохгүй. Ээж өөрийгөө зовоогоод байгаа юм. Ердийн л хэрэг шүү дээ. Харин ийм хэрэг элбэг байгаа нь тоогүй. Намайг баривчлах гээд байна уу?! Яасан ч баривчлахгүй. Гэхдээ тэгэх юм гэж санахад эцгийн д ч бай, нагацынд бай, хаана ч байсан адилхан баривчилна шүү дээ. Эсвэл би нууц байдалд орох хэрэг үү? гэв.

Тэрээр инээд алдав. Нөгөө Саша Панкратов өөрснийхнөөсөө нуугдах юм гэнэ.

–Софья Александровна хэтрүүлж айгаад байгаа нь ч үнэн л дээ гэж Михаил Юрьевич түүнтэй санал нийлээд –Гэхдээ улс төрийн хэрэг нэг ийм шинжтэй байдаг юм. Юу гэвэл, та давж заалдах бүрийдээ энэ хэрэгт улам олон хүн, улам олон байгууллагыг татан оролцуулж, нөгөө хэрэг чинь дорхноо хөөж сагаад ирдэг юм.

Саша Михаил Юрьевич руу гайхшран харлаа. Энэ намын гишүүн биш, улс төрд огт хамаагүй хүн яг үнэн юм ярьж байх ажээ.

–Би намдаа итгэдэг, тийм учраас түүнээс зугтах бодолгүй байна гэж Саша хэллээ.

Саша Хуучин талбай дээр өглөөгүүр ирэв. Китайгородын хэрэм байсан газар том том нүх харлаж, олон үеийн настай тоосго цасан дор энд тэнд овойно. Саша Төв шалган байцаах комиссын тохилог том саарал байшинд орж, үүдэнд байгаа өрөөний хуваарь дээрээс Сольцын тасалгааны дугаарыг олоод хоёрдугаар давхарт гарав.

Урт хонгилын хана дагаад олон хүн ээлжээ хүлээн чимээгүй сууна. Сольцын тасалгаанаас хөх ноосон даавуу костюмтай, цагаан цамцтай зангиа зүүсэн нэг залуу гарлаа. Саша түүнийг тийшээ орж уулзсан хүн гэж санаснаас гадна хүлээж байгаа улсаас хэн нь ч хөдлөөгүй учир өөрөө тэр өрөөний хаалгыг татав.

Цэлгэр том өрөөнд хоёр ширээ байх ажээ. Үүдний хавьд байгаа жижгэвтэр нь нарийн бичгийн даргынх бололтой, тасалгааны гүнд буй нүсэр томынх нь цаана Сольц сууж байна. Тэрээр лагс хүнд биетэй, сэгсгэр буурал үстэй, ахархан хүзүүтэй, монтгор хамартай, “туулайн” уруултай, нэрт шатарчин Эммануил Ласкертэй төстэй хүн аж. Түүний хажууд түшмэл царайтай нэгэн бөөрөнхий эр бичигнүүдээ барьж өгөн гарын үсэг зуруулж байна.

Сольц завгүй байгааг Саша үзээд үүдний тэндэх сандал дээр суув. Сольц түүн рүү харсан боловч нүд нь жаахан харалган учир чухам хэн орж ирснийг ялгаж чадсангүй, гэхдээ зөвшөөрөлгүй хэн ч орж ирэх ёсгүйг мэдэж байгаа болохоор нэгэнт орж ирээд сууж байхыг үзэхүл нарийн бичгийн дарга оруулсан байх нь, тэгэх ёстой юм байлгүй гэж бодоо биз. Түшмэл гарын үсэг зуруулах цаасаа ч шургуулсаар л. Энэ цааснууд нь шийтгэгдсэн намын гишүүдэд шүүхээс оноосон ялын бичиг ажээ. Нөгөө түшмэл шийтгүүлсэн хүний овог нэр, намд байсан хугацаа, эрүүгийн хуулийн зүйл анги, ял эдлэх хугацаа энэ тэрийг товчхон танилцуулж байгаагаас Саша тэр цааснуудын учрыг ойлгожээ. Гэхдээ түшмэлийн хэлж буй хуулийн зүйл ангийн тухай мэдэх юм даан ч байхгүй. Сольц доод уруул нь унжчихаад зовж гутарсан царайтай, хөмсгөө зангидан гарын үсгээ үг дуугүй зурах агаад намаас хөөгдөж байгаа хүмүүсийн шийтгүүлсэн ялнаас ч дор, шал өөр муухай юмны тухай бодож байгаа мэт санагдана.

Саша энд цагаа ололгүй санаандгүй орж ирснээ таамаглаж, энд байх эрх байхгүй гэж ойлговч босоод гараад явчихаж чадсангүй. Одоо явчих юм бол ийшээ дахиад хэзээ орж ирж чадахыг бүү мэд, ерөөсөө орж ирэхгүй ч юм уу. Энэ хонгилд сууж байгаа хүмүүс Сольцтой уулзах гэж хүлээж байгааг мань хүн тун сая л ухаарав. Тэд нар хэдэн сараар ч хүлээж байгаа байж магадгүй.

Сольц гэнэтхэн уур нь шатаж, буурал толгой нь салганан, гар хуруу нь чичигнэн ширээгээ хий тэмтчив.

—Дөчин метр төмөр утасны төлөө найман жил өгнө гэнэ ээ!

—Хорин зургадугаар зүйлийн “б”.

—Зүйл, зүйл... Дөчин метр утсанд найман жил!

Түшмэл цаас руугаа тонгойж гүйлгэн харав. Тэгээд царай нь дахин хэнэггүй болов. Хэргийн материалыг ёсчлон бичсэн байна. Тэгэхлээр Сольц хичнээн бархирлаа ч гэсэн ялыг өөрчлөх эрх байхгүй.

Ялыг өөрчлөх эрхгүй, шийтгүүлсэн хүнийг намаас хөөх ёстой, тийнхүү хөөсөн шийдвэрийг мань хүн өөрөө батлах ёстой, уур уцаараа энэ түшмэлд гаргаад ямар ч утгагүй гэдгийг Сольц өөрөө мэдэж байгаа билээ.

Түүний харц дахиад Саша дээр туслаа. Үүдэнд суугаа энэ танихгүй хүнд бас уур нь хүрнэ. Юун хүн юм бэ? Яагаад энд байж байна?...

Яг энэ мөчид Сашагийн түрүүн буруу таньсан нөгөө хөх ноосон даавуу костюмтай нарийн бичгийн дарга залуу орж ирлээ. Тэрээр Сольцтой олон жил цуг ажилласан туршлагатай нарийн бичгийн дарга учир Сольц ямар нэгэн шийтгэлээс болж уур нь шатаж, бас хөндлөнгийн хүн энд байгаад бухимдаж байна гэдгийг дор нь ухаарчээ. Гэтэл тамхи авах гэж буфет руу очоод ирэхийн хооронд энэ хөвгүүн энд орчихсон байдаг чинь нарийн бичгийн дарга хүний л алдаа.

Сольц Саша руу чичирсэн хуруугаараа зааж,

–Үүнд юу хэрэгтэй юм бэ? гэж асуув.

Нарийн бичгийн даргын түргэн харцнаас “Юу хэрэгтэйгээ бушуу хэл, битгий мунгинаад бай!” гэсэн үг Саша олж хараад тэр даруй бослоо.

–Намайг дээд сургуулиас хөөсөн юм...

–Юуны чинь бас дээд сургуулиас вэ? Сургууль энд ямар хамаа байна! Та нар чинь юу гээд цөмөөрөө наашаа яваад байгаа юм бэ? гэж Сольц хашгичив.

–Тээврийн дээд сургуулиас... гэж Саша өгүүлэв.

–Энэ нөхөр тээврийн дээд сургуулийн оюутан, сургуулиасаа хөөгдсөн байна... гэж нарийн бичгийн дарга ажил хэрэгч байдалтай өгүүлээд – Түүн рүү ойртоод оч гэж аяархан хэлэв.

Саша Сольцын ширээ рүү ойртоод,

–Намайг ханын сонин, нягтлан бодох хичээл дээр гарсан маргаан хоёроос болж сургуулиас хөөсөн юм гэв.

–Юун ханын сонин, юун нягтлан бодох хичээл вэ? Та надад юу хэлэх гээд байна вэ?

–Тэр хэргийг улс төрийн хорлон сүйтгэл гэж үзсэн юм.

Сольц ер нь энд юу болж байгаа, яагаад энэ хүн өрөөнд нь орж ирж, шүүхийн ялын тухай чагнаж байгаа, яагаад ямар нэгэн ханын сонин, нягтлан бодох гэх мэтийн юм яриад байгаа энэ тэрийг ерөөс ойлгоогүй бололтой Саша руу бүлтийтэл ширтэв.

Нөгөө түшмэл хэрэг бүрдүүлэх, шийдвэрлэх талаар тогтоосон журмыг тоомсорлохгүй бол ийм л байгаа юм даа гэсэн шиг өөртөө эрэмшсэн албаны хэнхэг дүрээр нигүүлсэнгүй, анзаарам төдий жуумалзан хямсайв. Сольц чухамхүү тэр журмыг ойлгохгүй байгаагаас болж л шат дамжлага алгасан өөр дээр нь хүмүүс ирээд байгаа хэрэг шүү дээ.

Сольц түшмэлийн нигүүлсэнгүй хямсайсныг анзаарчихжээ. Тэрээр Саша руу хөмсөг зангидан шагайж харснаа гэнэтхэн тайвширч,

–Бүгдийг дууд гэж хэлэв.

Саша зогссон чигээрээ байв.

–Та юу гээд зогсоод байгаа юм бэ? Эндээс яв! гэж Сольц дахин хашгирав.

Саша ухран холдлоо. Нарийн бичгийн дарга өөр рүүгээ ир гэж дохиод,

–Хэнийг дуудах вэ? гэж аяархан асууснаа “ББХ (б) Н-ын ТШБК-ын намын коллеги” гэсэн тамгатай хуудас өмнөө гаргав.

Яг ингэхтэйгээ зэрэг Сольц өөрийнх нь хэрэгт холбогдолтой бүх хүнийг дуудаж байгаа юм байна гэдгийг Саша сая ухаарч, сүүлийн хэдэн сард огт тэгээгүйгээ анх удаа зүрх нь булгилан, хоолой нь зангираад явчихлаа.

Нарийн бичгийн дарга түүнийг хүлгэлзэн харж байв.

–Баулин, намын байгууллагын товчооны нарийн бичгийн дарга хэмээн Саша нэрлэж эхлэв.

Нарийн бичгийн дарга залуу нэрийг цаасан дээр бичих зуур,

–Албан тушаал нь хэрэггүй, тэр огт хэрэггүй хэмээн яаруулав.

–Глинская, Янсон, Руночкин... Манай хүүхдүүдийг болох уу?

–Бушуухан хэлж үзээч ээ!

–Полужан, Ковалёв, Позднякова гэж хэлэх зуур

Саша ард нь нөгөө түшмэл хүний нэр, хуулийн зүйл ангиа үглэж эхлэхийг сонсов.

–Гүйцэв үү?

–Гүйцсэн.

–Хэзээ цуглуулах вэ?

–Маргааш болох уу?

–Хэл хүргэж амжих уу?

–Амжина.

–За харайлга.

Саша үүдэнд очоод эргэж харвал Сольц түүн рүү хэрсэн бух шиг харж байв.

“Намын коллеги таныг энэ оны нэгдүгээр сарын 17-ны гурван цагт нөхөр Сольц дээр ирэхийг урьж байна”. Тэгээд дуудагдсан улсын нэрс. Харин Сашагийн нэрийг л оруулсангүй, түүний нэрийг хэн ч асуугаагүй. Инээдэмтэй юм болжээ, гэхдээ энэ ямар хамаа байх билээ. Заргаа авлаа. Ингэнэ гэдэгт Саша эргэлзээгүй. Сольцод ямар ч албан байгууллага, ямар ч бичиг цаас, ямар ч шийдвэрийн шаардлага байхгүй. Бүгдийг дууд! гээд л гүйцээ. Мань хүн өрөөнд нь ороогүй бол, бас нарийн бичгийн дарга алдаагаа засахаас өөр аргагүй болоогүй бол юу ч бүтэхгүй байсан шүү дээ. Санах ч юм биш. Түүнээс гадна Сольцын уурыг шатаасан нөгөө түшмэлийн инээмсэглэл их хэрэг болсон. Одоо хэрэг ингээд бүтэх нь! Бүтлээ!

Гэлээ ч гэсэн сэтгэл нэг л сэвтэй... Ханын дагуу сандал дээр чимээгүй суусан энэ хүмүүс. Ойр дотныхныхоо хувь заяа хэрхэн шийдэгдэхийг хүлээж байгаа тэвчээртэй, хэл амгүй энэ хүмүүс. Пролетарийн диктатур өөрийгөө хамгаалах ёстой гэдэг ч гарцаагүй зүйл! Тэглээ ч гэсэн тэр хонгилын агаар хүний зовлон нэвт шингэсэн байна. Нөгөө дөчин метр төмөр утаснаас болж найман жилээр яллагдсан тэр нэгэн үл таних хүн. Саша түүний явдалд ямар нэг гай тарьсан биш биз, хүний урдуур ороод өршөөл ивээлийг нь булаачихсан биш байгаа?

Гэвч тэрээр нас залууг ч хэлэх үү, амьдрахын хүслэнд автаж явааг ч хэлэх үү, албаны урамгүй хана даган суусан чимээгүй улсын тухай бус, өөрийнхөө тухай, өөрийнх нь зовлон дууссан тухай бодохыг хичээлээ.

Саша нарийн бичгийн даргыг нь алгасан өрөөнд нь ороход Глинская утсаар ярьж байв. Захирал түүнийг хармагц таньж, эхлээд гайхасхийн, дараа нь айсхийн ширтсэнээ харилцуураа алгаараа таглаж,

–Юу гэж явна вэ? гэв.

Саша дуудлагаа өмнө нь тавив.

Цаадах нь түүнийг уншчихаад,

–Намайг яагаад дуудаж байгаа юм бэ? Баулин дээр оч гэж балмагдан гүвтнэв.

Тэрээр тун хөөрхийлөлтэй харагдах ажээ.

–Та гарын үсгээ зурна уу?

–Яагаад, яагаад? Намын хороо руу оч хэмээн Глинская гүвтнэнэ.

–Үүнийг танд хүргэхийг надад даалгасан юм. Гарын үсгээ зурчих!

Глинская харилцуураа сая тавьж хуудсыг авав. Тэгснээ гэнэтхэн “чи” гэх болж,

–Чи Сольц дээр очсон юм уу? гэж асуув.

–Тийм

Тэрээр хуудсыг харсаар. ТШБК-ын намын коллеги оролцож байна...

Мэдээж Рязанов, Будягин хоёрын хийж байгаа ажил ингэх л ёстой байсан л даа. Очиж их хурлын өмнө ингэж байдаг. Тэрээр мань Сольц эсвэл Ярославский, аягүй бол Рузутак ч магадгүй, тэд нарын хэн нэг нь их хурал дээр үг хэлэхдээ Панкратовт тохиолдсон энэ явдлыг ирээдүйн залуу мэргэжилтэнтэй нүнжиггүй сэтгэлээр харьцаж байгаа жишээ болгон дурдахыг дотроо төсөөлөн бодлоо. Төгсөх ангиас хөөсөн, тушаалд нь өөрөө гарын үсэг зурсан. Тийм ээ, гарын үсэг зурсан, намын байгууллагын товчооны шийдвэрт захирагдаж тэгсэн. Гэхдээ тэрээр ахлах ангиас оюутан гаргахыг хориглосон бичиг ирсэн гэдгийг Баулинд сануулж байсан. Түүнийг хэрэгсээгүй юм чинь одоо өөрөө л хариуцна биз. Глинская Саша руу харж инээмсэглээд,

–Энэ ч долдугаар сургуулийнхан мөн дөө. Шүлэг, шоглол энэ тэр гээд л ... гэв.

Саша хуудсыг түүн рүү ойртуулав.

–Та гарын үсгээ зурна уу.

–Би очно.

–Гарын үсгээ зурчих л даа!

Тэрээр хөмсөг зангидсанаа нэрийнхээ ард гарын үсэг зурлаа.

Баулин дуудлагыг уншаад хорсолтой инээмсэглэж,

–Оройгоор л авираад байна уу, нисэж ойчихгүй биз? гэв.

Тэгээд Сашад биечлэн доромжлуулсан хүний царай гарган байж хуудсан дээр гарын үсгээ зурав.

Янсон нүднийхээ зузаан шилний цаанаас Саша руу харж харцанд нь горьдлого нэгэнтээ тодрох шиг болсноо хэдэн давхарт очихыг асуув.

Ангийнхан нь нөгөө хуудсыг гар дамжуулан үзэв. Руночкин баярлан,

–Толгойгоо маажицгаах вий гэснээ – Ковалёв, чи одоо гэмших үү? гэж асуув.

–Сашка, чи эр хүн гэж Позднякова өгүүлэв.

Болгоомжтой Роза Полужан,

–Ялалт уу? гэж аяархан асуув.

Сольц харваас Сашаг мартчихжээ. Тэрээр өрөөнд нь найман хүн орж ирж буйг гайхан хараад ямар нэг зөвлөгөөн хийлгэхээр зарлуулсан юм байх гэж бодов. Гэвч хуанли дээрээ юу ч тэмдэглээгүй аж.

Глинская тэр хоёр танил бөгөөд мэндлэхээр гараа өгөхөд нь Сольц түүнийг таньж дүй муутайхан босож цөгцгөнөв. Боссоныг нь харвал нуруугаар тун намхан хүн аж.

–Тээврийн дээд сургуулийн хэрэг гэж нарийн бичгийн дарга тайлбарлав.

Ингэлээ гэж Сольцын санаанд юу ч орж ирсэнгүй, тэрээр тээврийн дээд сургуулийн хэрэг гэж огт мэдэхгүйн гадна харалганы харгайгаар Сашаг таньсангүй. Гэвч сурсан зангаараа гар дохин нөгөөдүүлийг суу гэж урив.

Глинская Сольцын өмнө ханын сонин тэнийлгэв. Сонин буцаж хуйлраад байсан тул Глинская захаар нь бэх уулгагч, харандааны хүнд аяга хоёрыг тавилаа. Сольц түүний хөдөлгөөнийг дэмий л дагуулан харна.

–Нөгөө шоглол шүлгүүд энэ байна гэж Глинская хэлэв.

Сольц сонин руу тонгойж харалган нүдээрээ анивчин харав.

Гахайн махан нухаш, ганц орц цагаан будаа бол

Борисын шарилд босгох боломжийн дээд хөшөө.

Тэрээр энэ шоглол шүлэг ямар учиртайг ойлгохгүй дээш хартал өөр рүү нь бүлтийн ширтэж буй Сашаг үзлээ. Тэгвээс өчигдөр өрөөнд нь сууж байсан залуу сая санаанд нь оров. Тэрээр шоглол шүлгийг дахин уншсанаа хөмсөг зангидлаа.

–Энд хувьсгалын эсэргүү юм юу байна?

–Наана чинь хэд хэдэн шоглол өгүүллэг бий гэж Глинская хариулав.

Сольц сонин руу дахин тонгойв.

Махруу ажил хөдөлмөр маяг боллоо.

Мань хүн гэтэл тэс өөр байлаа.

Уртын аянд яваа мэт тэмдэглэл юугаа гээчихнэ.

Уншаагүй байсан хэрнээ бүхнийг бас мэднэ.

–Октябрийн хувьсгалын арван зургаан жилийн ойд зориулсан дугаар гэж Баулин хэлэв.

Сольц саяынхыг хэлсэн хүн хэн болохыг мэдэх гэж оролдон цугларсан хүмүүсийг харалган нүдээ онийн байж харлаа. Цайвар хонгор үстэй хөөрхөн Надя, Саша, атигар хазгар Руночкин, айхаараа айчихсан Роза, арга баран балмагдсан Ковалёв энэ тэр түүний өмнө сууж байв.

–Октябрийн хувьсгал шоглол шүлгийг халаагүй гэж Сольц ширүүн хэллээ.

–Гавшгайчуудын зураг дор бичсэн байгаа юм гэж Баулин зөрлөө.

Өөртэй нь хэн маргаж буйг Сольц сая үзлээ.

–Хуучин цагт гагцхүү дээдэст зориулж л шоглол бичихийг хориглодог байсан. Тэглээ ч гэсэн зохиосоор ирсэн.

–Хөдөлмөр “маяг” боллоо гэдэг зөв гэж үү дээ? хэмээн Баулин өөрийнхөөрөө зүтгэв.

–Хөдөлмөр, хөдөлмөр! хэмээн Сольц татвасхийж – Хөрөнгөтний үндсэн хууль ч гэсэн хөдөлмөрийн тухай үгээр л эхэлдэг юм. Чухам ямар хөдөлмөр, юуны төлөө хөдөлмөр вэ? гэдэгт л юмны учир бий. Энэ шоглол шүлэгт хөдөлмөрийн эсрэг юм юу байна? гэв.

–Харахгүй юу...

–Залуухан залуухан амьдралыг яаж баллаж байгааг чинь харж байна хэмээн Сольц өмнөө суугаа залуусыг заагаад – Та эднийг яаж зовоож, яаж тарчлааж байгааг харж байна. Ильич “Та нар коммунизмын үед аж төрөх болно” гэж чухам эд нарын тухай хэлсэн юм. Гэтэл та эдэнд ямаршуухан коммунизм өгч байна даа! Та энэ хүнийг дээд сургуулиас зайлуулсан байна, энэ хүн хаачих вэ? Ачигч болох уу? гэхэд Янсон,

–Энэ ч ачигч л хийж байгаа л даа гэж өгүүлэв.

–Бид түүнийг сургаж байна, энэ чинь манай ирээдүйн зөвлөлтийн мэргэжилтэн шүү дээ. Гэтэл та түүнийг гудамжинд гаргаж байна. Яасан гэж тэгэв? Шоглол шүлэг бичлээ гэж тэр үү? Залуу насанд өөрийн гэх эрх бий. Түүнээс нэгдүгээр эрх нь хөгжилдөх эрх.

Тэрээр Глинская руу аанай л дүй муутайхан эргэж,

–Эдний насан дээр бид нар ч гэсэн хөгжилдөж байсан. Одоо эд нар хөгжилдөж байна, сайхан хэрэг шүү дээ! Залуучууд хөгжилдөж байгаа бол тэд сайхан байна гэсэн үг, тэд бидэнтэй хамт байна гэсэн үг. Гэтэл та тэднийг тас цохиж байна. Нэг нэгэндээ л шоглол шүлэг бичиж л дээ... Тэгэхгүй гээд эд нар чинь хэндээ бичих юм бэ? Надад бичих үү? Намайг мэдэхгүй шүү дээ. Тэгэхлээр эд нар хэнээрээ тоглоом хийх болж байна? гэв.

–Хөөснийг районы намын хороо баталсан гэж Баулин анхаарууллаа.

–Баталсан! Баталсан гэнэ шүү! Та нарын ажил чинь яасан сайхан шуурхай юм бэ! гээд Сольц хүрлийгээд явчихав.

Сургууль дээр ямар байснаа бодвол энд овоо өөртөө итгэлтэй байгаа Глинская,

–Яах вэ? гэж эвлэрэнгүй асуув.

–Буцааж ав! хэмээн Сольц шийдвэртэй ширүүн хариулав.

Залуус гадагшаа гарлаа.

Руночкин нүдээ долийлгож,

–Тэмдэглэх хэрэгтэй гэв.

–Би дэмжиж байна гэж Надя баярлан өгүүлэв.

–Би өөр тийшээ явах ёстой гэж Роза татгалзав.

–Би ч гэсэн явья даа гэж урамгүй царайлсан Ковалёв хэлэхэд Руночкин,

–Лозгачёвг мэнд хүргээрэй гэж захив.

Надя тэр хоёрт хэдэн рубль байж таарчээ.

–Манайхыг дайрч хөрөнгөө жаахан нэмье гэж Саша санал тавив.

Мань хүн гэртээ ороод ээжийгээ тэвэрч үнсэв.

–Ээж ээ, танилц! Намайг буцааж авахаар болсон... Ура!

Софья Александровна уйлчихлаа.

–За боль доо! гэж Саша өгүүлэв.

Ээж нь нулимсаа арчаад инээмсэглэв. Тэглээ ч гэсэн сэтгэл нь түгшүүр дүүрэн байжээ.

–Нина утасдсан.

–Бид нар тэднийхээр орно оо.

Нина гэртээ байсангүй. Хонгилд Варя утсаар ярьж байв.

Саша харилцуурын товчыг дарж утсыг нь таслаад,

–Алив явцгаая! гэв.

–Хаашаа? гээд Варя хөөрхөн Надя руу сониучирхан харав.

–Зуу татаж, зууш амсыя.

Харуй бүрий түргэн нөмөрч гудамжны дэнлүү аслаа. Саша өвөл цагийн оройн хөл шуугиантай Арбатад дуртай. Бүх юм ёсоор болж, бүх юм байдаг байдгаараа боллоо. Нөгөө бүх юм эцэс болж мань хүн хуучин янзаараа Арбатаар алхалж явна.

Афанасьевийн гудмын өнцөг дээр тэдэнтэй цааны арьсан оготор дээлтэй, бүсэлхийгээ хүрсэн урт чихтэй якут малгайтай Вадим тааралдав.

–Хойт туйлыг эзэмшигч! За, бидэнтэй явья!

–Азаа тэмдэглэх нь үү? гэж Вадим дор нь таамаглаж асуулаа.

–Яг.

–“Канатик” руу очигдоо, ёстой гоё газар гэж Вадим Надя руу хараа гүйлгэх зуур санал болгов.

–Нина ийшээ ирэх ёстой.

Тэд огцомхон эгц шатаар доошилж намхан адартай, бүдүүн бүдүүн дөрвөлжин баганатай “Арбатын нүхэнд” орж, мухрын булангаас нэг сул ширээ олж суув. Пивоны мухлаг ч гэхэд хэцүү, ресторан ч гэхэд хэцүү энэ газраас асгарсан пиво, гал тогооны үнэр холилдон эхүүн үнэр ханхална. Баганын хоорондох намхан нуман тотгонд хазгай дүүжилсэн болхи хийцтэй ханын гэрэл сүүтийн гэрэлтэнэ. Тайзан дээр гэртэйгээ их гарын морин хийл заларч, сандал дээр саксофон бүрээ тавиастай байх нь хөгжимчид хэдийнээ ирсний шинж.

Саша хоолны цэсийг ширээн дээгүүр өгөөд,

–Юу захиалцгаах вэ? гэв.

–Яасан үнэтэй юм бэ хэмээн Надя санаа алдав.

–Сүрэл, цэвдэг хоёрыг үзэх үү гэж Руночкин санал гаргав.

–Ногооны зууш, цэлцэгнүүр хоёр идэх гэж энд ирээгүй шүү гэж Саша зөрлөө.

–Гагцхүү “Какао-шуа” дарстай кофе уух гэж л энд ордог юм шүү дээ гэж Вадим зоогийн газраас салдаггүй хүний янзтай өгүүлэв.

Зэргэлдээх жижигхэн ширээнээ цэнхэр дөлтэй спиртен тулган дээр кофены данх байх агаад хоёр гэдрэг банди бяцхан нүдэн аяганаас дарстай кофе тамшаалсан шиг сууна.

–Бид нар өлөн байгаа гэж Саша өгүүлээд –Варя, чи юу идэх вэ? гэв.

–Нарийн махан хуурга.

Банди нартаа нэг шил архи, охиддоо нэг шил улаан дарс, хүний тоогоор нарийн махан хуурга захиалав.

–Өөр өөр хоол захиалах нь ашигтай гэж Вадим өгүүлжээ.

–Өө, Нина ч ирлээ гэж үүд рүү харж суусан Варя өөртөө хэлэх мэт аяархан өгүүлэв.

Нина тэдэн дээр ирж,

–Бүр мухарт шигдэцгээчихсэн байх юм... гэж уриалгахан хэлснээ –Сашенька, чамд баяр хүргэе хэмээн түүнийг үнсэж –Чиний зурвасыг уншингуут цөмийг нь ойлгосон. Би ч эргэлзэхгүй байсан л даа гээд Варя руу хяламхийж –Чи бас энд байгаа юм уу... гэв.

–Би ч бас энд байна.

–Макс мэдээгүй байгаа нь тоогүй гэж өгүүлэх зуур Нина Вадим, Руночкин хоёрын завсар орж суув.

Хөгжим нижигнэлээ... “Сонин хөөрхөн нимбэгнүүд минь, Сонягийн тагтан дээр ургаж байна...” Зөөгчид намхан давчуухан завсраар явдлаа түргэтгэн шогшицгоов.

–Сольц ч хүн юмаа гэж Руночкин хэлэв

–Даан ч дэндүү уцаар гэж Надя хэлэв.

Вадим нарийн махан хуурга захилах зуур,

–Саша шаналахын зовлонг тууллаа. Гэтэл шаналахгүйгээр гэж хэлтэл... Саша түүний үгийг тасдан,

–Шаналагсдыг би үзэн яддаг гэв.

–Прудоны хэлснийг дууриалгаж байх шив хэмээн Вадим Надягийн өмнө даналзаж, --Би бол дарлагчийн дараагаар дарлагдагчийг бас юунаас ч илүү үзэн яддаг. Гэхдээ янз бүрийн байдал байх... Жишээлбэл энэ... гээд хажуугийн ширээ рүү хялсхийлээ.

Нөгөө хоёр бандийн дэргэд хөөрхөн гэлтэй архинд идэгдчихсэн царайтай хүүхэн хэдийн ирээд суучихжээ.

–Нийгмийн хор гэж Нина хэллээ.

–Гаж үзэгдэл ч байж болох юм гэж Вадим зөрөв.

–Гаж нь ч биш, нийгмийн хор нь ч биш, ердийн янхны явдал гэж Саша хэлээд –Энэ хүүхэн яагаад ийм мөр хөөж яваа нь надад сонин биш, энэ хүний сэтгэл зүйн талаар эргэцүүлж бодох хүсэл алга. Харин манай Нина, Варя, Надя энэ тэрийг бол би хайрлах, хүндлэх, дээдлэхэд бэлэн байна. Хүн ёс суртахуунтай, түүгээрээ малаас ялгарна. Тэгэхдээ хүний амьдралын зорилго бол шаналахдаа биш гэв.

Варя хөгжмийн аяыг даган,

–“Ялдам даруухан чамд бид хайртайсан... Янз янзын л юм үзлээ, явахгүй гэдэг хүүхэн байдаггүй дээ”.

–Яагаад завхай дуунд ингэж дурлаж байна вэ? гэж Вадим асууснаа, –Хонгор сэтгэл төрөл арилжиж, хөөрхий банди хөсөр хаягдан, түүнийг хаана нутаглуулсныг хэн ч мэдэхгүй болно. Хүн шаналж байна, гол утга нь тэр юм гэж өөрөө хариулав.

–Чи улаан гол битгий маажгаад байгаач гэж Саша үгийг нь тасдав.

Вадим уруулаа хямсайж,

–Үгүй ер, чи яасан хүлцэлгүй юм бэ гэв.

–Чи битгий гомд, чамайг гомдооё гээгүй байна. Гэхдээ шаналал гэдэг бол чамд бол хийсвэр, харин намайг бол дайраад гарсан зүйл гэж Саша өгүүлээд –Одоо сан хөмрөгөө нэг тоолоод орхиё, дахиад нэг шил авах юм гараад ирэх ч билүү гэв.

Эрэгтэйчүүдэд нэг лонх, эмэгтэйчүүдэд нэг нэг мөхөөлдөс авах мөнгө гарлаа.

–Яарах л хэрэггүй шүү, оройгоо даахаар сунгая гэж Вадим анхааруулав.

–Варя, чи маргааш хичээлтэй хүн гэж Нина сануулав.

–Би хөгжим сонсмоор байна.

–Үүнийг битгий оролд, яахав сууж л байг гэж Саша хэлэв.

Тэрээр Варяг баяр цэнгэлтэй байлгахыг боджээ. Өөрөө ч аз жаргалтай байлаа. Гэхдээ энэ нь мань эр бүх хүнд нотолж үзүүлсэн дээ ч биш. Тэрээр арай илүү дорвитой нэг зүйлийг хамгаалж чадсан, тэр бол энэ залуусын итгэлийг хамгаалсан явдал. Хүмүүс өмгөөл ивээлгүй байдгийг одоо ухамсарч, чухам энэ нь хэзээ ч байгаагүйгээр сэтгэлийг нь зовооно. Руночкин түүний оронд байсан бол шал тоохгүй хаячихаад л яваад өгөх байсан. Надя Позднякова байсан бол жаахан уйлж уншиж байгаад бас яваад өгөх байсан. Вадим ийм явдалд орооцолдсон бол дорхноо шалдаа буух байсан.

Гагцхүү Варя л Сашагийн энэ явдлыг төдийлөн тоогоогүй билээ. Хэрвээ Варяг өөрийг нь сургуулиас хөөсөн бол мань хүнд баярлахаас өөр юм байхгүйсэн. Тэрээр Сашатай хамт ресторанд сууж, тэгээд уулгын газар, маягийн хувцастай залуус, хөнгөн хөгжмийнхөн, хацраа пумбайлган үлээж буй бүрээчин, дохиураа ухаан жолоогүй сэлгүүлж буй бөмбөрчин энэ тэр бүсгүйд маш сайхан юм шиг санагдана. Зэргэлдээх ширээний хүүхнийг хоёр согтуу юм өөрснийхөө ширээ рүү аваачих гэж хэзээний эргүүлдэн нөгөө хоёр гэдрэг банди түүнийг өмөөрч чадахгүй хулчийн сууна. Хүүхэн хараал тавин уйлагнаж, зөөгч түүнийг хөөж гаргана гэж сүрдүүлнэ.

–Азарган нохдын явдал хэмээн Саша хар нүдээ онилгов.

–Орооцолдохын хэрэггүй гэж Вадим хэлснээ Сашаг тогтоох арга байхгүйг мэдэх тул тэр даруй зам тавьж өглөө.

Саша босож, түгдийсхийн мөрөө займчсаар нөгөө ширээ рүү очоод ёозгүй инээмсэглэн,

–Больцгоох юм биш үү? гэв. Тэрээр хатуу ч гартай, зодолдохдоо ч чадамгай билээ.

Цаад хоёр нь ягаан цамцтай, нэг нь нарийн эсгий гуталтай, нөгөө нь жигтэйхэн өргөн шалбуур өмдтэй, увайгүй хүйтэн царайтай, ичих нүүрэндээ илэг наасан шижээргүй хоёр годил ажээ.

Эсгий гуталт нь өрөөсөн гараараа Сашаг тоомсоргүй зайлуулахад нөгөөдөх нь тэр хоёрыг салгах гэж байгаа янзтай.

–Боль доо, залуус минь! хэмээн дундуур нь түрэн орж ирэв.

Энэ эвлэрүүлэгч л эхлээд цохиод авдаг аргыг Саша эрхбиш мэдэх учир түүнийг нэгэнтээ огцом цохилоо. Ингэж цохиулсан хүн гэдсээ тэврэн хугасхийж, ам нь хий ангалздаг билээ. Саша нөгөө этгээд рүү эргэтэл цаадах нь алхам ухартусангаа ширээ дайрч, сав суулга хангинан, хүүхэн муухай чарлаж, хоёр гэдрэг банди суудлаасаа босон харайлаа... Бүрээчин тэр зүгт хялайн хацар нь түмбийж, төгөлдөр хуурч эргэж харсан хэрнээ хуруунууд нь даруул дээгүүрээ жирэлзэж, бөмбөрчин дохиураа гялалзуулсаар... “Хау ду ю, ду ю, мистер Браун... Хау, ду ю, ду ю, ду ю, ду ю, ду!...” Хөгжимчид хөгжмөө тоглон бүх юм ёсоороо байна, ардууд минь, үнэгэн шогшоо, танго бүжиг хийцгээ, “какао-шуа” дарстай кофе ууцгаа, хүн тоох юм болоогүй, санаанд орохын хэрэггүй, хар л даа одоо ингээд дуусчихлаа... Эсгий гуталт, шалбуур өмдөт хоёр ширээ рүүгээ явж байна, нөгөө хар нүдэд суучихлаа, зодоонд оролцсон нэг долир нөхөр бас суучихлаа, нөгөө хоёр банди тооцоогоо хийчихээд хүүхнийг дагуулаад явчихлаа, зөөгч тэдний ширээний бүтээлгийг сэгсэрч байна... Ардууд аа, бүх юм ёсоороо байна!

–Тэд нар бидний гарахыг хүлээж байгаад гадаа гарсан хойно хоргооно доо гэж Вадим хэлэв.

–Хулчийчихжээ! гээд Нина инээд алдлаа.

Саша зодолдохдоо тайван байсан хэрнээ одоо дотор нь бачимдан хачин оргино. Саша биеэ барихыг оролдлоо.

–Варя, хоёулаа явж бүжиглэе...

Хөгжимд зугуухан вальс эгшиглэнэ. “Романа, чи минь наддаа үүрд заяажээ...” Саша, Варя хоёр тайзны өмнөх давчуухан зайд бусдын хараанд өртөн бүжиглэж байв. Юу л гэж бодвол бодоцгоож байг, пад алга! Нөгөө хоёр ч мань эр рүү бас хялайж байна, тэр ч бас пад алга! Мань хүн вальс-бостон хийж байгаа юм чинь... “Рамона, чи минь наддаа үүрд заяажээ...” Варенька гэдэг аюулын хөөрхөн охинтой бүжиглэж байгаа юм чинь... Бүсгүй түүнийг инээмсэглэн харж, бахархан байна, тэрээр саяхан жигшин буруушааж байсан хүүхнээ өмөөрч гудамжны баатар шиг авирласан. Варя үүнийг бахархахын сацуу аль нэгэн өөриймсөг зүйл мэдрэх шиг болов. Мань хүн сургууль дээрээ үлгэр жишээ сурагчийн дүр гаргахыг оролддог шиг Саша бас ухамсартай хүн болох гээд байгаагаас биш хэрэг дээрээ энэ хоёр адилхан бус уу. Варя түүн рүү инээмсэглэн харж, биеэ наалаа. Хөгжим уйлагнан, бүрээчин ихэр татаж, бөмбөрчний дохиур агаарт зогсох шиг болж, төгөлдөр хуурч тонгойхоор тонгойжээ... “Цэцэглэх хаврын цагт хаа ч хэсүүчилж явсан, цэцэн зүүдний ачаар чамтайгаа золгосон

байнам”.

–Сайн байна, сайхан бүжиглэж байна гэж Сашаг хэлэхэд Варя санал гаргав.

–Нөгөөдөр мөсөн гулгуур дээр очих уу?

–Заавал нөгөөдөр байдаг нь юу билээ?

–Бямба гараг хөгжимтэй. Чи гулгадаг биз дээ?

–Нэг үе гулгадаг л байлаа.

–Очье л доо?

–Тэшүүр маань хаа байгааг ч мэдэхгүй л байна.

“Оюутан Панкратов буруугаа хүлээснийг харгалзан түүнийг хатуу донгодож, сургуульд буцаан авсугай”.

Баярт явдал болсонгүй. Түүнийг сургуулиас хөөсөн нь хамаг амьтныг бужигнуулсан атал буцааж авсан нь хэнд ч хүртээлгүй өнгөрөв. Гагцхүү Криворучко оюутны шинэ үнэмлэхэд нь гарын үсэг зурахдаа,

–Би чиний төлөөнөөс баяртай байна гэж өгүүлжээ.

Хуучин ширүүн дориун энэ хүн албан тасалгаандаа хоногоо хүлээж байгаа орь ганцаараа өрөвдөм амьтан болж хувирчээ.

–Таныг яаж байна? гэж Саша асуув.

Криворучко буланд буй хураалттай хавтаст хэрэгнүүд рүү дохиж,

–Ажлаа өгч байна гэв.

Тэрээр нүсэр том бичгийн ширээний нүднээс тамгаа гаргаж ирэв. Оюутнууд энэ ширээг усан онгоцны тавцан гэнэ. Криворучко оюутны цалин, нийтийн байр, тасалбар, захиалга энэ тэрийг мэддэг учир оюутнууд түүн дээр их ирдэг билээ.

–Энэ зуураа ярихад би чиний нагац ахыг танина. Бид нар нэг намын байгууллагад байсан юм. Аль хэзээ л дээ, хорин гурван оны үед. Бие нь сайн биз дээ?

–Сайн.

–Уулзахаараа мэнд дамжуулаарай.

Саша өөрөө хэргээс мултарсан атал Криворучко чадаагүй болохоор аз дайрсандаа санаа нь зовов.

–Та нөхөр Сольц дээр орвол яасан юм бэ?

–Миний хэргийг Сольц яаж ч чадахгүй. Минийх бол өөр хүнээс хамаарна... гэснээ Криворучко Саша руу харалгүй, өөртөө хэлэх мэт –Тэр тогооч давсыг нь ихдүүлдэг хүн гэж нэмж өгүүлэв.

Тэгээд хөмсгөө зангидлаа. Ямар тогоочийг хэлж байгааг нь Саша ойлгов.

Саша дараа нь Лозгачёв руу очлоо. Цаадах нь түүний амжилтад баяртай байгаа мэт инээмсэглэн угтав.

–Криворучко дээр очсон уу?

Саша Криворучкотой уулзсаныг мэдэж байсан хэрнээсээ тэгж асуужээ.

–Үнэмлэх, пропуск хоёроо бүрдүүлж авсан гэж Саша хариулав.

Баулин орж ирэнгээ Сашагийн хариултыг сонсоод,

–Тамга Криворучкод байгаа юм гэж үү? хэмээн Лозгачёвоос тоомсоргүй асуув.

–Шинэ хүн даваа гарагаас орно.

–Цаад авгай чинь тамгаа авчихвал болох л байсан даа.

Глинская өөрийгөө тамга дарахад дэндүү дээгүүр албан тушаалтай гэж үзэж байгааг ойлгуулан Лозгачёв дал мөрөө хавчив.

Тэд нар огт юу ч болоогүй мэт, буруугаа ч мэдэрсэн юмгүй, сэтгэлийн сэв ч байхгүй, тэр үед тэгэх л шаардлагатай байсан, одоо буцаагаад авсан бол өөр байж болно... гэсэн шиг хуучин янзаараа ажлаа явуулж, хэрүүл маргаанаа хөөцөлдөж байна. Тэгэхлээр Саша ч өөр болох ёстой гэх шиг...

Тэр хоёр өөрийнх нь дэргэд Глинскаягийн тухай доогтой ярьж, түүнийг нүд үзүүрлэж байгаагаа нуухгүй байна, ийм илэн далангүй байгаа чинь итгэлийн илрэл бус гэж үү?

Энэ бүхэн бол “Панкратов, чи ч гэсэн өөр болох ёстой. Одоо чи дарагдсан, дахиад яавал хоёр дахь удаагаа мултарч чадахгүй. Сольц хол, бид ойрхон байна, тэгэхлээр биднийг бараад. Чи бол хал үзэж, хашир суугаагүй залуу хөвгүүн, тэгээд л эндчихэж л дээр, хэнд ч тохиолдож болох хэрэг, бид ойлгож байна. Одоо чи Криворучко гэж хэн болохыг мэдлээ, бидэнтэй нийлж түүнийг дар. Нийтлэг дайсантай хүмүүсийн хооронд л итгэл үүсдэг юм.” Нөхрөөр чинь чамайг хэн болохыг танина” гэдэг үг хуучирсан! “Дайснаар чинь чамайг хэн болохыг танина” – асуудлыг одоо ингэж л тавина” гэж байгаа үг юм.

–Криворучко чамд гомдол мэдүүлэв үү? гэж Лозгачёв асуулаа.

Эд нартай орооцолдохын хэрэг юун. Дарагдсан хүн нь Саша бус эд нар, эд нар ширээ мөргөсөн болохоос мань хүн мөргөөгүй. Үүнийг санаж яваг.

–Надад юу боллоо гэж мэдүүлэх вэ дээ, би ямар намын коллеги биш.

Лозгачёв хөхүүлэн инээд алдаж,

–Ямар ч атугай зовлон нэгт нөхөд шүү дээ гэв.

–“Нөхөд ий” гэж Саша дооглонгуй асуугаад – Түүнийг чинь буцааж аваагүй байгаа биз дээ гэв.

Баулины хүйтэн харцанд сэрэмжилж анхааруулах янз байгааг Саша олж харав. Чухам тэр харцнаас болоод эгдүү нь хүрээд явчихлаа. Юунаас сэрэмжлэн анхааруулж байна вэ? Дахиад

хөөхөөс үү? Гар чинь богинодох байлгүй! Нүүрээ түлчихсэн байж ялсан хүний царай гаргах гээд байж гэнэ. Энэ бол чухамдаа Сольц чамайг өршөөсөн хэрэг биш, нам өршөөсөн хэрэг. Тэгээд нам гэдэг чинь бид нар, тэгэхлээр бид нар л чамайг өршөөсөн... гэх маягтай. Үгүй ээ, эрхэмүүд минь, та нар хараахан нам биш!

Лозгачёв түүн рүү доогтой сониучирхан харж,

–Криворучког буцааж оруулна гэж бодож байна уу? гэв.

–Намайг буцаагаад л авлаа.

–Чи бол өөр хэрэг, чи алдаа гаргасан, Криворучко бол егзөр...

–Түүнийг тухайн үедээ улс төрийн алдаа гаргасны учир намаас хөөж байсан, тэгсэн хэрнээ буцааж авсан, тэгэхлээр нийтийн байрны тухайд мэдээж...

Баулин Сашаг анхааралтай ажиглан олбогт сандалд суух зуур,

–Шинэлэг янзтай байх чинь вэ, чи чинь хуучин ингэж ярьдаггүй байсан шүү гэж өгүүлэв.

–Хуучин надаас ийм юм асуудаггүй байсан. Харин одоо бол асууж байна.

–Хуучин чи Криворучкогос “Би мэдэхгүй, түүнийг танихгүй, хоёр үг ч сольж яваагүй” гэж зайлсхийгээд байсан хэмээн Баулин хэллээ.

–Одоо ч гэсэн давтан хэлье. Би мэдэхгүй, түүнийг танихгүй, хоёр үг ч сольж яваагүй.

–Тийм гэж үү? Хэмээн Баулин хорон санаатай асуув.

–Панкратов, чиний буруу хэмээн Лозгачёв сургамжилж, – Нам эгнээгээ цэвэрлэж байх ёстой...гэхэд Саша түүний үгийг тасдан,

–Юуны өмнө албан тушаал горилогчдоос гэж хэлэв.

–Чи хэнийг хэлэх гээд байна? хэмээн Лозгачёв хөмсөг зангидав.

–Тодорхой тэр гэсэн хүн алга, албан тушаал хөөцөлдөгчдийг бүхэлд нь хэлж байна.

–Уучлаарай, тийм биш шүү хэмээн Лозгачёв толгой сэгсэрч, –Нам үзэл суртлын хувьд туйлбаргүй, улс төрийн хувьд дайсагнасан этгээдүүдээс эгнээгээ цэвэрлэдэг, гэтэл чи юуны өмнө албан тушаал горилогчдоос гэж байна. Тэр ч бас хэрэгтэй гэдэг нь маргаангүй. Гэхдээ тэгж сөргүүлж тавихын учир юу байна? гэв.

Лозгачёвын хуурамч төлөв дуу, хүйтэн цэвдэг царай, цээжилсэн албархаг үгийнх нь болхи мохоо энэ тэр Сашагийн дургүйг хүргэнэ.

–Нөхөр Лозгачёв, хүнд элдэв хаяг наахаа боливол яана вэ! Та нар энэ талаар хэдийн дасгал

сургууль хийцгээсэн. Албан тушаал хөөцөлдөгч нэг этгээд намд ахмад большевик Криворучкогийн бүх алдаанаас илүү гай тарина гэж би хэлж байна. Криворучко бол намын хэргийн төлөө зүтгэж яваад тэр алдаануудыг гаргасан, гэтэл албан тушаал хөөцөлдөгчдөд өөрийнх нь турсага, өөрийнх нь суудлаас өөр эрхэмлэх юм гэж байхгүй.

Чимээгүй болцгоолоо.

Дараа нь Баулин,

–Панкратов, чи базаж хэлэхдээ барагтайхан байна гэж сунжруулан өгүүлэв.

–Хэр маань энэ гэж Саша хариулав.

Тэр хоёр хэлсэн юмыг нь мушгиж гуйвуулах нь мэдээж, Саша Лозгачёвын өрөөнөөс гармагцаа үүнийг ойлгов.

Хэнтэй илэн далангүй ярихаа мөн олов оо! Мань хүн тэд нараас айхгүй. Гэхдээ л мундаг хэрэг.

Хичээлийн танхимд Саша хуучин суудалдаа суулаа. Нэрийг нь журналаас дарж амжаагүй байв. Тэглээ ч гэсэн энэ бүх явдал дууссан гэхэд нэг л итгэсэнгүй. Сольцтой болсон явдал ч худлаа юм шиг санагдана. Бодитой юм гэвэл сургууль, Баулин, Лозгачёв, гутарсан Криворучко... энэ тэр л байна.

Тэрээр хүн дүүрсэн трамвайгаар харьж явав. Гадаа юу юугүй харуй бүрий бууж, эртлэн ирдэг өвлийн бүүдгэр орой нөмрөн айсуй. Эрүүндээ сийрэгхэн шар сахалтай, сөхөвчит малгайнх нь чих уранхай, оготор нэхий дээл рүү нь унжсан олхио муутай нэгэн эр Сашагийн өдөөс харан суужээ. Тоногтой том эсгий гутлаараа нэг уутаа хавчиж, өөр нэг уутаа суудал дээр тавьсан байх агаад үзүүр ёзоортой ямар нэгэн хатуу юм чихсэн тариачны эв хавгүй энэ уутнууд давчуухан вагонд хэн хүнгүй тээр болж байна. Тэрээр сандчин ийш тийшээ харж, үйлчлэгч авгай түүний буух газар нь болмогц хэлнэ гэсээр атал хаа буухыгаа дахин дахин асууна. Гэтэл тэрхүү хайгуулдан буй харааны угт нэг л догшин, бараг хэрцгий шинж байх шиг Сашад санагдав. Энэ олхиогүй эр гэртээ бол шал өөр хүн байх.

Янз бүрийн нөхцөлд хүн яаж өөрчлөгддөг тухай санааг Саша гэртээ очсон хойно өдрийн тэмдэглэлдээ бичихийн тулд гүүр, зам барилгын дэвтрийнхээ хавтсан дээр тэмдэглэв. Тэрээр тэмдэглэлээ нэг бичиж, нэг больж байсан бол одоо тогтмол хөтөлж байхаар эрс шийджээ.

Үдэш орой болж Саша унтах гэж байтал Катя гэнэтхэн утасдав.

Яг хуучин янзаараа харилцуураас чимээ гарахгүй байснаа ойр ойрхон дохио ёнгинож, буцааж тавиваас утас дахин дуугарлаа.

–Катя, чи юү?

–Таньсангүй юү? гэх дуу нь хотын захын автомат утаснаас ярьж байгаа мэт тэртээ холоос сонсдов.

–Чамайг дуугарахгүй байхад яаж таних билээ?

–Дуугарахгүй байхад... Хашгираад байх газар ч биш байх аа. Яаж аж төрж байна даа?

–Аж төрж л байна, чамайг бодоод л байна.

–Бодоод л байна гэжээ... Охин дутаа юү?

–Охидоо тараагаад алдчихсаан. Чи яажшуу байна?..

–Яаж, яаж... Маруся чамайг санаад байна гэнэ. Марусяг санаж байгаа биз дээ?.. Чамд дурлалчихсан гэнэ, хар нүдтийгээ авчир гээд байдаг.

–Би бэлээн. Хэзээ очих вэ?

–Очих вэ.. горьдов оо бас, би нөхөртөө л авгай нь.

–Нөгөө механикчтайгаа суусан уу?

–Механикч... Техникч-механикч, тэнэг хулгайч.

–Балгачихаа юу даа?

–Чи аягалж өгөө юү?

–Хэзээ уулзах вэ?

–Бид чинь хаа уулзах юм бэ? Гадаа гучин градус хүйтэн байгаа, чи хамаг юмаа хөлдөөчихнө.

–Маруся биднийг хүлээж байгаа шүү дээ.

–Хүлээж байгаа шүү дээ... Түүний нөхөр нь хүрээд ирсэн. За яахав. Охидын талбай руу ирээрэй.

–Тэгээд хаашаа явах вэ?

–Хаачдагийн уул руу...

–За тэгвэл маргааш Охидын талбай дээр шүү. Зургаад уу?, долоод уу?

–Аа бас, их санаатай. Зургаад л гүйгээд очно гэж горьдоо юу!..

За ингээд Катя эргээд гараад ирдэг байж. Тэгтэл ч тэр хүүхний тухайд дандаа төрдөг хүсэл нь түүнийг дахин эзэмдэж авлаа. Ер нь ч тэр хүсэл унтарч бөхөөгүй л дээ. Тэр хоёр ес билүү арван сард уулзсан, одоо нэгдүгээр сар гээд бодоход дөрвөн сар өнгөрчээ. Бүсгүй мэдээжээр хүнтэй суугаагүй, Марусягийн нөхөр ирсэн гэдэг ч худлаа, мань хоёр маргааш тэднийд л очно, чухам тэгэх гэж л түүний тухай дурссан хэрэг. Дандаа тойруулж ярьдаг хачин бүсгүй!

Тэрээр орондоо ороод түүний тухай бодох тусам түүнийг хүсэх нь улам нэмэгдэж байв. Маргааш түүний хатсан уруулыг үнсэж, тэвэрч энхрийлнэ гэж бодохоос мөд нойр хүрч өгдөггүй.

Хонгилд хонх тодхон дуугарах шиг болоход Саша дорхноо сэрэв. Шөнө, нэг цаг өнгөрч байна. Дөнгөж зүүрмэглэж байсан байх. Хонх дахин шургуу шийдэмгий дуугарлаа. Саша майк, богино өмдтэй чигээрээ хонгил руу очиж хаалганы гинжийг мултлав.

–Хэн бэ?

-- Байрны захиргаанаас явж байна.

Саша хашааны цэвэрлэгч Василий Петровичийн дууг таниад түлхүүрээ эргүүлэв.

Үүдэнд Василий Петрович, түүний ард пальто, үстэй малгайтай нэг танихгүй залуу, бас улаан ягаан түдүүлэн товчтой шинельтэй хоёр цэрэг зогсож байх ажээ. Сайхь залуу эхлээд Василий Петровичийг, дараа нь Сашаг мөрөөсөө зайлуулаад орж ирэхэд нэг цэрэг нь үүдэнд хоцорч, нөгөө нь Василий Петровичийг даган гал тогооны өрөө рүү очиж арын хаалганы тэнд байраа эзлэв.

–Панкратов уу?

–Тийм

–Александр Павлович уу?

–Тийм.

Залуу Сашагаас болгоомжилсон харцаа салгалгүй, Арбатын... тоотод суудаг Панкратов Александр Павлович гэдэг иргэнийг нэгжих, баривчлах зөвшөөрлийн бичгээ сарвайв.

Тэр хоёр Сашагийн өрөөнд оров.

–Үнэмлэх бичигнүүд ээ!

Саша сандлын ар дээр өлгөсөн пиджакнаасаа паспорт, оюутны үнэмлэх хоёроо гаргалаа. Залуу тэдгээрийг анхааралтай шалгаж үзээд ширээний өнцөг дээр тавив.

–Зэвсэг бий юу?

–Надад зэвсэг байхгүй.

Залуу ээжийнх нь өрөөний хаалга руу дохиж,

–Тэнд хэн байна? гэв.

–Ээжийн өрөө.

–Сэрээчих.

Саша өмдөө өмсөж, цамцаа дотуур нь хийгээд оймс, шаахайгаа углав. Сайхь бүрэн эрхт Сашагийн хувцаслахыг хүлээзнэн пальто, малгайтай чигээрээ зогсоно. Саша босоод, ээжийгээ гэнэтхэн сэрээж айлгачихгүйн тулд өрөөнийх нь хаалгыг аяархан нээв.

Ээж нь унтлагынхаа цагаан цамцны энгэрийг бариад орон дээрээ бөгтийн суух бөгөөд буурал үс нь дух, нүд рүү нь унжжээ. Тэрээр Сашагийн араас орж ирсэн бүрэн эрхтийг гөлөрсөн харцаар хялайн харлаа.

–Ээж ээ, бүү санаа зов... Намайг нэгжиж байна. Энэ бол эндүүрэл. Учир нь олдоно. Тайван хэвтэж бай.

Ээж нь Сашаг анзаарахгүй, үүдэнд зогсож байгаа танихгүй хүнийг зөрүү хялайн харна.

–За ээж минь, энэ эндүүрэл гэж би хэлсэн шүү дээ, тайвширч үз, хэвт.

Саша өрөөндөө буцаж орж ирэхдээ ээжийнхээ хаалгыг хаах гэсэн боловч бүрэн эрхт онгорхой байх ёстой гэх шиг хаалгыг тэр чигт нь орхиулав. Бүрэн эрхт бол зөвхөн гүйцэтгэгч ажилтан учраас маргаж эсэргүүцээд ямар ч ашиггүй. Итгэлтэй, хөгжилтэй байх хэрэгтэй, тэгвэл л ээжийгээ тайвшруулж чадна.

–Та юу нэгжих гэж байгаа юм бэ, би танд өөрөө өгчих юм байж магадгүй шүү?

Бүрэн эрхт пальто, малгайгаа тайлж буланд өлгөв. Тэрээр хар хөх костюмтай, зангиа зүүсэн бараан цамцтай, бүдүүрч эхэлсэн, албан газар бишгүй тааралддаг ердийн нэгэн залуу аж.

Ширээн дээр сургуулийн дэвтэр, хичээлийн тэмдэглэл, сурах бичгүүд хэвтэнэ. Бүрэн эрхт тэдгээрийг барьж үзэн, хуудсыг нь эргүүлж, гүйлгэн хараад нямбай давхарлан тавьж байна.

Гүүр, зам барилгын дэвтрийн хавтсан дээрээ Сашагийн өнөөдөр “Трамбайнд яваа тариачин сандарсан хөөрхий амьтан, харин гэртээ бол дураараа дургидаг эзэн” гэж бичсэн нь залуугийн анхаарлыг татав.

Тэр дэвтрийг паспорт, оюутны үнэмлэхийн дэргэд тавилаа.

Ширээний нүдэнд янз бүрийн бичиг баримт, гэрэл зураг, захидлууд байв. Бүрэн эрхт захидлын агуулгыг тоохгүй, гагцхүү хэн бичсэнийг нь сонирхоно. Тэгээд гарын үсгийг нь гаргахгүй бол асууна. Саша товчхон хариулна. Захидлууд бүрэн эрхтэд хэрэггүй бололтой тэдгээрийг баруун гар тийш нь ялгаж тавина. Төрсний гэрчилгээ, дунд сургуулийн гэрчилгээ, ажлын газрын тодорхойлолт болон бусад бичиг баримтыг байранд нь үлдээж, комсомол, үйлдвэрчний батлахыг зүүн гар тал руу тавилаа.

–Та яагаад миний комсомолын батлахыг авч байна?

–Би одоохондоо юу ч аваагүй байна.

Хүүхэд ахуйн болон сурагч үеийн зургийг тоохгүй, гагцхүү том улстай хамт авахуулсан зургийг л сонирхоно. Тэгээд энэ хэн бэ, тэр хэн бэ? гэхчлэн асууна.

Ээж нь бослоо. Саша ор хяхтнаж, шаахай шалан дээр чирэгдэж, халаад байдаг шүүгээний хаалга торхийх энэ тэрийг сонсжээ. Гэтэл ээж нь халаадын оронд унтлагынхаа цамцны дээрээс дан дээлээ хайш яйш углаад гарч ирэв. Царайчлан инээмсэглэж Саша дээр очоод чичирсэн гараараа үсийг нь илэв.

–Иргэн гуай, та өрөөндөө сууж байгаарай гэж бүрэн эрхт хэлэв.

Түүний дуунд албархан захирах аяс илт. Софья Александровна иймэрхүү дуунаас хэзээний айдаг болохоор хүүдээ хор хүргэх ямар нэг юм хийчихсэн мэт айн гилбэлзэж, толгойгоо түргэн түргэн дохиж гарав.

–Эсвэл, ээж бид хоёр шалан дээр хэвтэх үү? гэж Саша инээмхийлэн хэллээ.

Тавиур дээрх номыг шалгаж байгаа бүрэн эрхт гайхшран эргэж харснаа юу ч хариулсангүй.

–Өрөөндөө сууж бай гэж Саша ээждээ хэлэв.

Ээж нь толгойгоо улам түргэн түргэн дохиж, бүрэн эрхгийн өргөн ууц руу айдас хурсан харцаар ширтсээр өрөө рүүгээ буцаж оров.

Эд нар Сольцын тухай мэдэж байгаа болов уу? Мэдэхгүй л байна даа, түүнээс биш ингэж зүрхлэхгүйсэн. Нэг газар л мэдээ саатсан хэрэг. Гомдмоор юм! Энэ будлиан их төвөг удна аа.

Бүрэн эрхт хувцасны шүүгээг онгойлго, пиджакны халаасаа эргүүл гэж тушаасанд тэндээс хаяг, утасны дугааруудтай тэмдэглэлийн дэвтэр гарав. Тэр дэвтрийг мөн ширээн дээр тавилаа. Бүрэн эрхт бүх юмыг нэгжсэн эсэхээ шалгаж өрөөг тойруулан хараад орны цаана нэг чемодан байгааг үзээд, онгойлго гэж тушаав. Гэвч дотор нь юу ч байсангүй. Энэ хүн үүргээ биелүүлж байгаа, нямбай, ажилд үнэнч түшмэл аж. Саша энэ хүний оронд байж байгаад нам түүнийг Улс төрийн ерөнхий газрын байгууллагад томилж, хэн нэгэн хүнийг нэгжиж баривчлахыг даалгажээ гэхэд энэ ажилд алдаа гарах нь зайлшгүй юм чинь цаад хүн нь ямар ч буруугүй байлаа гэсэн мань хүн яг энэ бүрэн эрхт шиг л ажиллах байсан. Хувийн гомдолдоо

хөтлөгдөж болохгүй, сая ТШБК-т нотолсон шигээ буруугүй гэдгээ дахин батална. Тэгэхээр энэ хүн хийвэл зохих ажлаа хийж байг л дээ.

–Нөгөө өрөө рүү орцгооё.

Ээж нь шүүгээ тохойлдон буурал толгойгоо бариад хаалга руу жишүү харан зогсож байв.

–Энэ нөхөр таны өрөөг шалгана. Ээж, суу.

Ээж нь нөгөө л байдлаараа зогссоор байснаа бүрэн эрхтийг очмогц жаахан ухрав.

Шүүгээн дээр Саша, Марк, ээжийнх нь эгч нарын зураг байжээ.

–Энэ хэн бэ?

–Миний дүү, Марк Александрович Рязанов.

Түүний дүү нь нөгөө цуутай Рязанов, Саша нагац дүү нь гэдгийг энэ бүрэн эрхт мэдэж аваг. Тэрээр энэ тухай яаж хэлье дээ, хэлчихвэл эд нар нэгжихээ больж, Сашаг баривчлахгүй орхино хэмээн энэ зуур туж бодож байжээ. Маркийг улс орон даяар мэднэ, Сталин ч түүнийг мэднэ. Тэгээд арчаагүй инээмсэглэн,

–Энэ нь бол Сашенька, жаахан байсан юм гэж нэмж өгүүлэв.

Бүрэн эрхт хөмсөг зангидсанаа зургийг авч гууных нь даруулыг тэнийлгэж, гаргаж ирээд ар талыг нь харвал ямар ч бичиг байсангүй. Тэгмэгц мань хүн зураг, гуу, тавиур, шил энэ тэрийг задгай чигээр нь шүүгээн дээр буцааж тавилаа. Софья Александровна олбогт сандалд лагхийтэл сууж хоёр гараараа нүүрээ таглан ёолон гаслав.

Бүрэн эрхт шүүгээний нүднүүдийг дутуу сугалж, гараа явуулан онгичив. Сандаасан цагаан хэрэглэлээс угаалгын шинэхэн үнэр ханхлах бөгөөд ээж нь Сашагийн ор дэрийг засахад ийм үнэр сэнгэнэдэг билээ.

–Намайг л нэгжих ёстой биз дээ гэж Саша хэлэв.

–Та нар нэг ам бүл юм гэж бүрэн эрхт хариулав.

Тэд Сашагийн өрөө рүү буцаж орж ирлээ. Араас нь Софья Александровна даган гарч ирэв. Нэгэнт нэгжлэг дууссан учир түүнийг өрөө рүүгээ буц гэсэнгүй. Ээж нь үүлгэртэж самгардан байснаа Сашаг аваад явчихна гэж бодонгуут сэхээ орж, нааш цааш бэгцгэнэн, чухам яах ийхийгээ мэдэхгүй, дэмий л Саша руу нэг ойртож, бүрэн эрхтийг хуламганан нэг харах ажээ. Цаадах нь ширээний ард суугаад нэгжлэгийнхээ протоколыг бичиж байв. Тэдний өдөр, тэднийд, тийм тоот зөвшөөрлөөр... Авсан нь: паспорт, дугаар; үйлдвэрчний батлах, дугаар; комсомолын батлах, дугаар; үйлдвэрчний батлах, дугаар; оюутны үнэмлэх, дугаар; тэмдэглэлийн дэвтэр. Тэрээр “Гүүр, замын барилга” гэсэн дэвтрийг барьж байснаа авахаа болихоор шийдэж хажуу тийш нь тавилаа. Тэгснээ,

–Гараа хаа угааж болох вэ? гэж асуув.

Софья Александровна үймрэн,

–Алив, би зааж өгье гэв.

Тэрээр шүүгээний татуургыг сандран таталж, цэвэрхэн алчуур олж аваад бүрэн эрхтийг гараа угааж байх зуур угаалгын өрөөний үүдэнд алчуураа барин зогссоноо түүнийг гарч ирэхэд нөгөө газар очсон хойно нь хүүгийнх нь хувийг энэ хүн хөнгөлж магадгүй... гэсэн шиг арчаагүй царайчлан инээмсэглээд алчуураа барив.

Бүрэн эрхт гараа арчаад хонгил руу гарч, нэг тийшээ утасдаж Арбат гэдэг ганц үгнээс өөр юу ч ойлгогдохгүй битүү утгатай юм хэлэв. Тэгээд харилцуурыг тавьж, ажлаа дууссан хүний ажиггүй царай гарган хаалга налаад зогсчихов. Хаалганы хажуу дахь цэрэг сул зогсож нөгөө нэг нь гал тогооноос хүрч ирэв. Одоо ар өврийн хаалга хоёулаа чөлөөтэй болж, цэвэрлэгч Василий Петрович ч яваад өгөв. Нэгжлэг дууссан тухай хөршийнхөнд хэн ч хэлээгүй атал хонгилд Михаил Юрьевич, Галя хоёр гарч ирэв.

Ээжийнх нь гар салгалан Сашагийн юмыг төхөөрч байна.

–Дулаан оймс хийгээрэй гэж бүрэн эрхт хэлэв.

–Бодвол идэх юм авах хэрэгтэй байх даа гэж Михаил Юрьевич даруухан өгүүлэв.

–Мөнгө гэж бүрэн эрхт хэллээ.

–Ээ чөтгөр чамайг, миний тамхи дуусчихсан шүү дээ хэмээн Саша гэнэтхэн санав.

–Би нөхрөөсөө аваад ирье.

Галя нэг хайрцаг “Бокс” авчирлаа.

–Саша, танд мөнгө бий юу? гэж Михаил Юрьевич асуув.

–Хэдэн юм байна.

Саша халаасаа ухав.

–Арван рубль.

–Хүрнэ гэж бүрэн эрхт хэлэв.

–Тэнд хямдхан юмтай мухлаг бий гэж нэг цэрэг нь хэллээ.

Саша умард руу ч юм уу, өмнөд рүү ч юм уу аль нэг мэдэхгүй хот руу явах гээд л юу авч явахыг нь түүнд зөвлөж байгаа юм шиг бүх юм ердийн байдалтай байлаа.

Бүрэн эрхт хаалганы хатавч түшээд тамхиа татаж, нэг цэрэг нь Галятай юм ярьж, нөгөө нь явган суугаад мөн тамхиа нэрж байна. Михаил Юрьевич Сашагийн сэтгэл санааг нь дэмжин инээмсэглэнэ. Саша бас өөдөөс нь инээмсэглэвч арчаагүй инээмсэглэж буйгаа өөрөө мэдрэн өөр яах ч аргагүй байна.

–Сашенька, юу юу хийснийг хар даа хэмээн Софья Александровна чичирсэн гараараа боодлынхоо захыг ярьж –Саван энэ байна, шүдний оо, сойз, алчуур, сахлын хутга.. гэвэл

–Сахлын хутга хэрэггүй гэж бүрэн эрхт хэлэв.

–Уучлаарай гээд ээж нь сахлын хутгыг авч –оймс энэ байна, солих дотуур хувцас, нусны алчуур..

Түүний хоолой чичирнэ.

–Сам энэ байна, энэ... нөгөө чиний ороолт...ороолт чинь...

Тэг тэгсээр үг нь уйлаан болж хувирлаа. Тэрээр өөрөөс нь хагацуулж, шорон руу аваад явж байгаа ганц хүүгийнхээ энэ юмнуудийг барилж үзэхдээ үнэхээр гол тасрам хэцүү байжээ. Софья Александровна олбогт сандалт суухад жижигхэн мариалаг бие нь мэгших аясаар нь чичигнэн байна.

–Та тайвширч үз, гайгүй, учир олдоно хэмээн Галя түүнийг аргадан мөрийг нь илбэж, –Нөгөө Алмазовын хүүг авч явчихаад, хэсэг байлгаж байгаад тавьчихсан байсан шүү дээ. Нэгэнт ийм болсон хойно одоо уйлаад ямар нэмэр байх билээ гэв.

Гэтэл Софья Александровна мэгшсэн хэвээр,

–Ингээд дуусах нь энэ, дууслаа дууслаа... гэж бүвтнэн үглэв.

Бүрэн эрхт цагаа харлаа.

–Юмаа аваарай!

Тэрээр тамхиныхаа ёзоорыг хаяж, нуруу цэхрэн хөмсөг зангидав. Харуулын хоёр цэрэг мөн цэгцэрч, ажилдаа орох нь тэр. Зөвлөгөө өгөхөө хэдийн больж, буугаа хөлдөө аван харгалзан дагахад бэлтгэв. Бүрэн эрхт баривчлагдсан хүнийг тууж гарах замаас холдохыг Михаил Юрьевич, Галя хоёрт гар занган дохив.

Саша пальто малгай хоёроо өмсөж боодолтой юмаа авав.

Нэг цэрэг цоожийг нь онгойлгох гэж дүй муутай ноцолдсоны эцэст арайхийн нээв. Энэ чимээг Софья Александровна сонслоо. Тэрээр чухам үүнийг хүлээн айж байжээ. Хонгил руу гүйж гараад пальто малгайгаа өмссөн Сашаг эхэр татан, хахаж цацан салгалсаар зуурч авлаа.

Михаил Юрьевич мөрнөөс нь зөөлхөн түшиж,

–Софья Александровна, битгий, нээрээ битгий уйл гэв.

Саша буурал үс нь сэгсийсэн ээжийнхээ толгой дээр үнслээ. Михаил Юрьевич, Галя хоёр ээжийг нь барин тогтоозноход тэрээр эхэр татан тэдний гартай ноцолдов.

Саша байрнаасаа гарлаа.

Гадаа байшингаас нь холгүй нэг машин хүлээж байв. Сашаг арын суудалд бүрэн эрхт, нэг харгалзагч хоёр дундаа суулгаж, нөгөө нэг харгалзагч нь жолоочийн дэргэд суулаа. Шөнийн Москвагийн гудамжаар чимээгүй явж ирэв. Шоронгийн чухам аль талаас ирснийг Саша ойлгосонгүй. Өндөр том төмөр хаалга нээгдэж машин нарийхан хашаа руу орлоо. Эхлээд харгалзагч нар, дараа нь Саша, эцэст бүрэн эрхт суув. Машин тэр дороо яваад өглөө. Сашаг жигтэйхэн зайтай, намхан адартай, нэг хоосон өрөөнд оруулав. Энэ нь тавилга ч байхгүй, сандал ширээ ч байхгүй, халтартсан туургатай, амьтны хөлд элэгдсэн цементэн шалтай, хлорын шохой ханхалсан байшингийн газар давхар ажээ. Энэ бол хүлээн авах байр гэдгийг Саша таамаглав. Баривчлагдагсдыг эндээс хориглох өрөө рүү нь хуваарилж, ийш тийш хэсэг бүлгээр нь явуулах ялтныг энд бүрдүүлнэ, өөрөөр хэлбэл энэ бол шоронгийн орох гарах хаалга, түүний эхний болон эцсийн даваа. Одоо хүлээн авах байр хоосон байлаа.

Эндээс зугтахын аргагүй тул бүрэн эрхт, харгалзагч энэ тэр Сашагийн хөдлөх бүрийг мөрдөхөө больсон байв. Тэд нар өөрсдийнхөө ажиллагааг хал балгүй дуусгаж, баривчилсан хүнээ хүргэх газар нь авчирсан болохоор түүнээс хойшхийг нь хариуцах ёсгүй ажээ.

–Энд зогсож байгаарай гэж бүрэн эрхт тушаачихаад яваад өгөв.

Хоёр харгалзагч бас харуулын байр руу явчихав. Тэндхийн нээгдсэн хаалганаас шинелийн нойтон цэмбэ, цэргийн хоол болох ногоотой шөлний үнэр тархлаа.

Саша боодолтой юмаа шалан дээр тавиад ханын дэргэд зогсознов. Түүнийг харгалзах хүн ч алга, харах хүн ч алга. Баривчлах ажиллагаа дууссан хэрнээ хорио хараахан эхлээгүйгээс ийм завсар гарчээ. Гэтэл ийнхүү ганцаараа хоцорсон энэ мөчид л мань хүн шинэ байдлаа хэдийн ухамсарлаж эхэлснээ өөрөө мэдрэв. Тэрээр ганцхан алхам хөдөлсөн ч гэсэн түүнийг болиулж, байсан газраа зогсож байхыг тушаана, мань хүн тэр тушаалыг дагахаас өөр арга байхгүй, энэ нь улам доромжлуулсан хэрэг болно. Тэгэхлээр тэгж доромжлуулах шалтаг гаргахгүй байх хэрэгтэй гэсэн үг. Гагцхүү тэгж гэмээ нь мань хүн өөрийнхөө нэр төрийг, эндүүрлээр ийшээ ирчихсэн зөвлөлтийн хүний нэр төрийг хамгаалж чадна.

Түрүүч цолтой цэргийн хүн түүнийг харалгүй хажуугаар нь өнгөрөхдөө,

–Нааш ир! гэв.

Саша боодолтой юмаа аваад араас нь явав. Сониуч зангаас өөр ямар ч сэрэл үүссэнгүй.

Хамгийн түрүүчийн халхны цаад талд нэг бичгийн ширээ байж байв. Сайхь цэргийн хүн суугаад нэг маягт гаргаж ирэв. Овог? Нэр? Төрсөн он? Онцгой тэмдэг? Шивээс? Сорви? Шархны ором? Түлэнхий? Мэнгэ?... Нүд, үсний өнгийг бичиж авлаа... Тамгын тосны

зөөлөвчирхүү юм сарвайж, маягтан дээр Сашагийн хурууны хээг даруулав. Юмыг нь бүртгэж авлаа: пальто, малгай, шаахай, ноосон цамц, өмд, пиджак, цамц.

–Мөнгө!

Мөнгийг нь тоолж үзсэнээ маягтад тэмдэглээд гарын үсэг зуруулав. Тэгээд ширээ рүүгээ хийчихлээ.

–Юмны чинь тасалбарыг танд авчирч өгнө гээд цэргийн хүн нэг хаалга руу зааж –Тийшээ ор! гэв.

Бяцхан тасалгаанд албаны хувцастай, нойрмогтсон нэгэн шалхгар бүдүүн хүн түүнийг тосож байжээ.

–Тайчаарай!

Саша пальто, малгайгаа тайлав.

–Шаахайгаа тайл!

Саша шаахайгаа тайлаад оймстойгоо үлдэв.

–Үдээсийг нь сугалаарай!

Бүдүүн хоёр үдээсийг ширээн дээр тавиад булан руу зааж,

–Тийшээ зогс! гэв.

Буланд чац хэмжих хуваарьтай босоо мод байв. Бүдүүн хэмжүүрийн соёог гүйлгэж Сашагийн толгойд тулгаад, ханын цаана сууж байгаа өөр нэг хүнд дуулгах гэж,

–Зуун жаран долоо! гэж чанга хэллээ.

Дараа нь Сашагийн пальто, малгайг баахан барилж үзсэнээ, дотрыг нь хутгаар ханзалж завсраар нь гараа явуулан, хэсэг тэмтрээд модон вандан дээр тавьж, костюм руу нь дохин,

–Тайл! гэв.

Саша пиджакаа тайлав.

–Бүгдийг нь тайл!

Саша майк, богино өмдтэй үлдлээ.

Бүдүүн эр өмд, пиджак хоёрыг нь тэмтэрч, дотрыг нь ханзалж, өмдний захны хажлагыг хуулсанаа тэлээг нь сугалж нөгөө үдээсний дэргэд тавиад өмд, пиджак хоёрыг вандан дээр шидчихэв.

–Амаа ангай!

Нойрмог нүүрээ Сашад ойртуулан амыг нь нэгжин харснаа, уруулыг чангааж байгаад ард нь юм уу шүдний завсар юм нуусан эсэхийг шалгав. Дараа нь майк, богино өмд рүү нь дохилоо.

–Тайл!

Тэрээр шивээс, сорви, түлэнхий, шархны ором хайсан боловч олсонгүй.

–Эргэ!

Өгзгөн дээр нь хүйтэн хуруу хүрэхийг Саша мэдрэв...

–Хувцасла!

Дараа нь Саша тэлээгүй өмдөө гараараа дэмнэн, үдээсгүй холхиндог шаахайгаа холхиулсаар харгалзагчид туугдан богинохон богинохон хонгилоор мушгиран явж, төмөр тороор торлосон хэдэн шатыг өгсөж уруудан хэсэг алхав. Харгалзагч түлхүүрээрээ шатны төмөр хайсыг тогшлон, цоож хяхтнах сонсдож, эргэн тойрон үхмэл өрөөнүүд, дүв дүлий төмөр хаалганууд.

Тэд нэгэн хонгилд ирээд зогсов. Тэднийг хүлээж байсан хянагч өрөөг онгойлголоо. Саша орлоо. Хаалга торхийн хаагдлаа.

Дөрөвдүгээр зуухыг Сталины шаардсан ёсоор хугацаанаас нь өмнө өгөх болж арван нэгдүгээр сарын гучны долоон цагт гучин таван градусын хүйтэнд асаалаа. Бас тийм хүйтэнд асаасан нэгдүгээр зуухны сүйрэл энэ удаа давтагдахгүй гэдэгт бүрэн итгэхээс нааш Марк Александрович явах учиргүй байв. Тийм учраас тэрээр мужийнхаа төлөөлөгчдөөс хоцроод дөнгөж нэгдүгээр сарын хоринд Москва руу гарчээ.

Төмөр замын цас цэвэрлэгч түрүүлэн одож албаны вагоныг уурын тэргэнд хэдийн залгасан ажээ. Салхи улин цас хунгарлан шуурч бүдэгхэн хэдэн дэнлүү энд тэнд дайвалзаж байгаа нь цахилгаан эрчим хүч металл хайлуулж байгаа газарт, чухамхүү заводад хэрэгтэй учир хот, төмөр замын буудал цахилгаанаар гачигдаж байдгийн гэрч тэр буй заа.

Төмөр замын буудлын бяцхан байшингийн зуухны дэргэд үйлдвэрийн захиргааны хэсэг ажилтан цугларчээ. Тэр даргыгаа Москва руу явахаас олон хоногийн өмнө бэлтгэж эхэлсэн боловч яг явахынх нь өмнө дуусгасан элдэв ажил явдлаа ярилцах ёстой ажээ. Тэд нар малгай, пальтоных нь зах цастай хэвээрээ, галош угласан нойтон эсгий гуталтайгаа Марк Александровичийн араас вагонд орж ирээд цасаа сэгсэрч, гутлаа дэвслэн, тамхи баагиулж үйлчлэгчийн ясыг хавгалзуулав. Тэрээр даргыг өөрийг нь явах болгонд тэгдэг ёсоороо вагонаа гялалзтал цэвэрлэж, дүнгэнэтэл халаасан билээ.

Марк Александрович үстэй пальто, малгайгаа тайлсан боловч халууцсан байлаа. Нарийн эсгий гуталтай болохоор хөл нь бүр ч халууцна. Чийдэн үе үе бүдгэрэвч хурц гэрэлтэнэ. Тэрээр Москвад очоод хэрэг болох баримт сэлтээ шалган нягталж бичиг цааснуудаа түргэн гүйлгэн харав. Төв хорооны сэдэвт үйлдвэрийг барьж дуусгах хугацааг анх удаа зааж 1937 оноор тогтоожээ. Түүнчлэн ширэм үйлдвэрлэх төлөвлөгөөг таван жилийн эцэст хорин хоёр сая тонн байсныг арван найман сая болтол буулгажээ. Энэ бол бодит хандлага ялсных. Тэгэхлээр өчигдөрхөн зориглож ам ангайдаггүй байсан орон сууц, механикжуулалт, нийгэм ахуйн барилга байгууламжийн тухай одоо ам мэдэн шаардах цаг болжээ.

—Марк Александрович аа, хөдлөх цаг боллоо гэж буудлын дарга үүдэнд ирж өгүүлэв.

Дүрэмт хар пальто, хар малгайтай, дэнлүү барьсан үйлчлэгч,

—Хөдөллөө шүү, нөхөд өө, хөдөллөө хэмээн уцаардуухан үглэж вагон дундуураа алхав.

Үдэхээр ирсэн хүмүүс үүд руу хошуурцгааж, вагонд хүйтэн агаар сэнгэнэн орж ирэв. Үйлчлэгч босгон дээр наалдсан цасыг хөлөөрөө унагаад хаалгаа хаалаа. Шүгэл тасхийхэд уурын тэрэгний яндан түүнийг залган хүнгэнэж вагон часхийснээ тэр даруй дайвалзасхийн төмөр замын уулзварыг түг түг тоолон түжигнэж эхэллээ.

Марк Александрович эсгий гутлаа тайлж, чемоданаасаа гэрийнхээ шаахайг гаргаж углаад хөлөө сэгхийлгэж хэдэнтээ алхав. Тэгснээ цонх руу очиж хөшгийг нь ярлаа.

Хэдхэн вагонтой галт тэрэг домна, мартен зуухны даланд гийсэн хот байрлаж байгаа толгойг тойрон цас бүрхсэн тал дундуур давхиж явна. Тэд нар дөрвөн жилийн өмнө ийшээ нүцгэн

газар ирж байсан бол одоо энд хоёр зуун мянган хүн ам, дэлхийн зиндаанд ярих үйлдвэр, улс оронд хэдийн нэг сая тонн ширэм, хэдэн буман тонн ган, гурван сая тонн хүдэр өгсөн аварга том үйлдвэр байж байна. Марк Александровичид хуучныг дурсан санах цаг байсангүй, энэхэн үед бодвол зохих юмаа л дөнгөж амжуулан бодож явлаа. Их хурал болох гэж байгаа болохоор мужийн төлөөлөгчдийн хамт түүрүүн Москва руу явчихсан Ломиназегийн тухай эргэн эргэн нэхэн санав.

Төв Хорооны гишүүн Ломиназег онолын алдаа гаргасан учир хамаг өндөр албан тушаалаас нь халж, эднийд хотын намын хорооны нарийн бичгийн даргаар, чухамдаа хот гэдэг бол үйлдвэр, хотын намын хороо гэдэг нь үйлдвэрийн намын хороо юм чинь түүнийг үйлдвэрийн намын хорооны нарийн бичгийн даргаар ирүүлсэн билээ. Рязанов арван есөн оны намын гишүүн, Ломиназе арван долоон оных учраас намын хувьд ахмад ч гэсэн насаар Марк Александровичтай чацуу. Түүнийг ухаалаг, нарийн аргатай, дайлайцтай, зоригтой, улс төрийн томоохон зүтгэлтэн гэж үздэг байжээ. Гэтэл их хурал дээр хуучин эсрэг бүлгийнхнийг шүүмжилбэл Ломиназе руу мөн дайрна, тэгэх юм бол үйлдвэр рүү аян хамтад нь довтолж мэднэ. Металл чухал зүйл, гэвч улс төр түүнээс ч чухал.

Марк Александрович байдлыг цэгнэн үзээд их хурал тайван өнгөрөх байх гэж бодов. Ялагчдын их хурал гэж нэрлээд байгааг нь бодсон ч тийм л баймаар. Үүний өмнөх гурван их хурал тэмцэлдэх үзэл санааны дор болж өнгөрсөн, одоо нам шинэ удирдлагаа тойрон нэгдэн нягтарч байгааг харуулах цаг болсон. Тэглээ ч гэсэн санаандгүй ямар ч юм болохыг хэн байг гэх вэ.

Марк Александрович тусгай вагон гэдгийг ор мэдэхгүй, зуухтай ачааны вагоноор эсвэл вагоны үүдний өрөө буюу дээвэр дээр ууттай юмаа үүрээд шинельтэйгээ Москва ордог байхад ямар нэгэн юмнаас болгоомжлох, санаа зовох юм даан ч байдаггүйсэн. Одоо мань хүн хэдэн зуун мянган хүний хувь заяаг шийддэг, эрх мэдэл ихтэй, намын чиг шугамын зөв гэдэгт хатуу итгэдэг, аль нэг эсрэг бүлгийнхэнтэй урьд ч нийлж яваагүй, одоо ч нийлээгүй түүнээс гадна Серго түүнд хайртай, Сталин түүнийг үнэлдэг ч гэсэн чухам одоо л бүх юмыг сайтар цэгнэн үзэх ёстой. Тухайн үедээ Марк Александровичид өөрт нь ч хамаагүй, түүний толгойлж байгаа хамт олонд ч холбогдолгүй алдаа хийсэн Ломиназег нэг жилийн өмнө тэднийд хотын намын хорооны нарийн бичгийн даргаар ирүүлснээс болж өөрт нь төвөг учрах вий гэдгээс бас болгоомжлох ёстой.

Гэтэл бас Саша гэнэтхэн ойлгомжгүй баригдчихсан байлаа... Тэрээр эгчийнхээ захидлыг аваад яах учраа олохгүй гутарч зовсон билээ. Явдлын учир байдлыг мэдэхгүйг ч хэлэх үү. Тоо бүртгэлийн багштай холбогдсон хэрэг бол баривчлах үндэслэл болохгүй. Юун төлөө Сольц Сашаг сургуульд нь буцааж оруулсан билээ дээ. Саша тэр нэгэн шөнө Сталины даруу биш зан, Лениний захидал... энэ тэр гэж ярьж байсан, юмны учир үүнд л байгаа вий. Тэр Лениний захиаг уншаа юу? Хаана, хэзээ, хэнийд вэ? Сталины даруу биш зан... Тэрээр энэ тухай зөвхөн өөрт нь л яриад зогссон уу? Өөр хэнд ярьсан бол? Өөрийнх нь бодол байсан уу, эсвэл бусдын ухуулсан санаа байсан уу? Хэн ухуулсан байх вэ? Зээ дүүгийнх нь явдал учраас мань хүн бүхнийг мэдэж авах эрхтэй, хэргийг нь маш нягт бодитойгоор мөрдөнө гэж горилох бас эрхтэй.

Марк Александровичийг Свердловскт ирэхэд мужийн гүйцэтгэх хорооны дэргэд суугаа

Үйлдвэрийн төлөөлөгч Киржак тосдог билээ. Марк Александровичийн шилжин суух ёстой Москва-Владивостокийн буухиа галт тэрэг хожигдож яваа тул буудлын дарга түүнийг вагоноос нь шууд засгийн газрын гишүүд болон бусад дээгүүр тушаалтад зориулсан өрөөнд авчрав.

Буфетны хүүхэн хачиртай талх, цай авчирч өглөө. Бие давжаа, уцаар уймраа болчихсон Киржак ажил байдлаа танилцуулав. Нийлүүлэгчид үүргээ ёсчлон биелүүлэхгүй байна, тээврийн хэрэгсэл дутагдаж байна, нөөц бодитой биш байна, санхүүхийнхэн чирэгдэл учруулж байна, мужийн байгууллагууд муу тусалж байна гэнэ. Марк Александрович Киржакийн энэ гоморхолд дасчихсан билээ. Тэрээр хангамжийн сайн ажилтан боловч хүнээс юм салгахдаа гойд сайн бус, тэр дутагдлаа ийнхүү гоморхлоор цагаатгадаг хүн. Марк Александрович Киржактай ярилцчихаад галт тэрэгний буудлын машин руу очив. Хүн явах зайг боодолтой, ууттай юм, хайрцаг саваар дүүргэжээ. Хүмүүс шал, вандан энэ тэр дээр суух нь сууж, хэвтэх нь хэвтэх агаад кассны дэргэд баахан амьтан овоорон, халуун устай буцалгуурын тэнд авгай хүүхдүүд гойд их шавжээ. Энэ бүхэн бол нэхий дээл, сийрсэн гутлаа халаагүй, нүүдэл хөдөлгөөнд дасаагүй, энэ зуур учраа алдаж, хөөрхийлэлтэй ядуурч үгүйрсэн хөдөө тосгон, газраас нь хөндийрүүлж үймүүлж бужигнуулсан тариачны Орос орон даруй мөн.

Марк Александровичийн хувьд энэ бол шинэ зүйл биш, улс орны аль ч зам дээр ийм л байгаа. Үүрсэн, барьсан юмтай, авгай хүүхдээ дагуулсан өчнөөн төчнөөн хүн өөрийнх нь үйлдвэрт мөн ирдэг. Тэгээд ч үйлдвэрийнх нь нийтийн сууцнууд яг л ийм хөлс хулмас, ногоо сармис, арьс хөрсний хурц нялуун үнэр нэвт шингэсэн байгаа. Түүхийн хатуу ширүүн хууль гэгч ийм ажгуу. Үйлдвэржүүлэлтийн хууль гэж энэ. Энэ бол нүд харалган, нүүр халтар, зэрлэг бүдүүлэг, уранхай тасархай хуучин хөдөөгийн эцэс, энэ бол хар амиа хоохойлох үзлийн эцэс. Шинэ түүх бүтэж байгаа нь энэ. Тэгээд ч бүхий л хуучин юм энэлгээ шаналгаатай, элэгдэл хаягдалтай нурж байна.

Марк Александровичийн суусан олон улсын вагон бараг хүнгүй байжээ. Тэрээр тасалгаандаа нэг хэсэг ажиллаад, бүр бүрий орохын үес буюу гурван цагт вагоны хонгил руу гарч ирэв.

Дугуйн нэгэн хэмийн доргионыг дэвссэн хивс эрхбиш зөөллөнө. Нэгээс бусад бүх хаалга хаалттай байв. Онгорхой хаалганаас эрэгтэй эмэгтэй хоёр хүн францаар ярих сонсдоно.

Тэгтэл хүүхэн хонгилд гарч ирээд Марк Александровичийг хармагц балмагдан инээв. Тэрээр хоосон хонгилд хүн байна чинээ бодолгүй халаад, гэрийн шаахайтай, үсээ янзлаагүй, бие засах газар очихоор гарч ирсэндээ бантлаа гэж Марк Александровичид бодогдов. Марк Александрович тэднийг унтаж байхад вагонд суусан болохоор урьд үзээгүй танихгүй орос хүн өөр рүү нь тиймэрхүү байдалтай байхад нь харж байна гэдэг хүүхэн хүнд яаж аятай байх билээ. Тэрээр том эвэр хүрээтэй шилтэй, гучин тав эргэм насны өндөр хүүхэн ажээ. Бие засах газраас буцаж ирэхдээ дахин нэг инээмсэглээд тасалгаандаа орж хаалгаа хаав.

Дараа нь хаалга нээгдэн мөн л чац сайтай, товир биетэй, Луначарскийтай төстэй нэг эрэгтэй хүн хонгилд гарч ирэв. Марк Александрович түүнийг хармагц хоёрдугаар Интернационалын удирдагчдын нэг, бельгийн нэрт социал-демократ гэж дор нь танилаа. Сар хэртэйн өмнө энэ хүн Японд очиж лекц уншихаар Зөвлөлт Холбоот Улс, Хятадаар дамжин өнгөрсөн тухай

сонинд мэдээ үзэгдсэн билээ. Марк Александрович тэгэхэд ийм мэдээ өнөөгийн олон улсын нөхцөлд өөрийн эрхгүй хэрэгтэй, шаардлагатай шинэ шинэ хэлхээ холбоо бий болж байгааг гэрчилж байна гэж бодсон ажээ.

Удаан хамт явах хүмүүсийн ёсоор тэр хоёрын хооронд яриа амархан хөгжлөө. Марк Александрович англи хэлэнд сайн, францаар санаагаа ойлгуулахтайгаа билээ. Тэгтэл ч сайхь бельгийн авгай саарал ноосон даавуу банзал, бүдүүн сэргэр хөхийг нь дурайлгасан ноосон цамцтай хонгилд гарч ирэв. Тэрээр энэ удаа мөн мишээсэн нь францаар ярьдаг замын хань таарсанд баярлан гайхсны илрэл бололтой.

Оросын өвөл, энгүй уудам орос нутаг, харилцаа холбоо, явах суухын бэрхшээл энэ тэрийн тухай ярьцгаалаа. Токио, Осака хоёрт дулаахан, Нагасакид халуун байхад энд хүйтэн байна. Жавар орос хүнийг сэргээн хөгжөөдөг бололтой. Сибирь, Уралыг дайран явж байгаа боловч нөгөө алдарт Кузбасс, Магнитын барилга байгууламжийг олж харсангүй гэж бельги хүн харамсан ярив. Вагоны цонхоор гагцхүү оросын алдарт цас л харагдах юм. Нөгөө оросын туршилтыг бас үзэх гэж бодсон хэмээн улиг болсон үг хэрэглэж буйдаа гэмших мэт инээмсэглэн нэмж өгүүлэв.

Тэрээр хоёрдугаар таван жилийн томоохон барилга байгууламжийг их хуралд зориулан нийтэлсэн зурагтай “Правда” сонины шинэхэн дугаар тасалгаанаасаа авчрав. Барилга байгууламжийг зуух, автомашин, трактор, комбайн, уурын тэрэг, машины дугуйн бүрээс, усан цахилгаан станц... зэргээр тэмдэглэсэн ажээ. Хуйлаатай даавуу нь нэхмэлийн комбинат, саахарын толгой нь ётон, элсэн чихрийн үйлдвэр, энэ нэг цагирагнууд нь холхивч гэхчлэн Марк Александрович тайлбарлаж өглөө. Бельги хүн сайшаан инээж байснаа энэ аварга том программ гагцхүү эдийн засгийн бусад салбар, юуны өмнө хөдөө аж ахуйг гаргуунд нь орхиж байж л биелнэ гэж өгүүлэв.

Марк Александрович иймэрхүү меньшевик маягийн үзэл, үндэслэгээг мэдэх билээ. Орос оронд хоёр дахь хувьсгал хийж байхад энэ эрхэм хүндэт ноёнтон, энэ парламентын малилзсан, улс төрийн бодлоготон нэгдэх хувьсгалыг ойлгоогүй шигээ одооныхыг бас л ойлгохгүй байна.

Марк Александрович улс төрийн маргаан үүсгэхийг хүсээгүй учир дуугүй өнгөрөв. Тэрээр хилийн чанадад олонтаа байж, гадаадын хүмүүстэй ярьж хөөрч сурсан ч гэсэн улс төрийн ярианаас зайлсхийдэг билээ. Тэртэй тэргүй хэн хэндээ юу ч нотолж чадахгүй юм чинь. Тэгээд одоо ч гэсэн энэ нэрт улс төрийн бодлоготонтой маргах хорхойгоо барьж чадав. Гэхдээ цаадахдаа өөртэй нь маргалдахаас айж байна гэж бодуулах дургүй байлаа. Энэ утгаар яривал Марк Александрович хор шартай, ер нь дэвжээнээс ялагдаж бууж сураагүй билээ. Тийм учраас хоёр жил ган цугтах үйлдвэрт ажиллаж Америкийн Нэгдсэн Улсад байсан тухай сэтгэгдлээ ярих зуур Нью-Йоркт үзсэн нэгэн инээдтэй явдлын тухай дурсав.

Янз хуучирсан, газар шүргэсэн хар даашинзтай, шувууны үүр шиг отготой хар эсгий малгайтай нэгэн тамиргүй эмгэн сүмээс гараад ирлээ. Тохойноос нь нэг бүсгүй дэмнэн байх нь ач нь бололтой, аягүй бол гуч нь ч байж магадгүй. Бүсгүй эмээгээ үүдний довжооны шатаар болгоомжтой буулган замын хажууд байсан “Паккард” машинд аятайхан суулгаж, энхрийлэн үнсээд хаалгыг хаав. Гэтэл нөгөө машиндаа арайхийж хүрсэн эмгэн чинь

жолооны ард суумагц мотороо асааж “Паккард” ухасхийн хөдлөөд гялалзаад алга болох нь тэр.

Марк Александрович энэ явдлыг элдвээр тайлбарлалгүй, гаансаа сайхан сорж байгаад зүгээр л ярьж өгсөн боловч ярианы чухам эгзэгтэй үед хэлсэн болохоор Америк гэдэг чинь цоо шинэ техникээр зэвсэглэсэн мөхөж яваа нийгмийн байгуулал гэсэн ёгт санаа байсныг ухаантай хүн ойлгохгүй байхын аргагүй. Марк Александрович ямархан түвшинд ярьж сурсныгаа ийнхүү тойруу замаар нарийн харуулсныг бельги хүн дотроо үнэлэв. Марк Александрович гадаадын хүний өмнө өргөн мэдлэг, хурц ухаан, цартай чөлөөт үзэл бодлоороо гайхуулах дуртай, өөрийнхөө улсад хүчтэй, эрх мэдэлтэй хүн бол чухам л ингэж байх ёстой гэж үздэг билээ.

Бельгийн авгай ёгт санааг ойлгосонгүй. Гэхдээ Марк Александровичийн ярьсан зүйл түүнд үнэхээр инээдтэй санагдсан бололтой зөндөө удаан хөхрөв.

Марк Александрович галт тэрэгний буудлаас Садово-Каретная гудамж руу, Зөвлөлүүдийн гуравдугаар байшинд очихоор явлаа. Зохион байгуулах комисс байрласан танхим хоосон байв. Төлөөлөгчид цөм ирчихсэн ч гэсэн жижүүрүүд байсан тул Марк Александрович бүртгүүлж, мандат, зочид буудлын бичиг, хоолны талон, “БХК(б) Н-ын 17-дугаар их хурлын төлөөлөгч” гэсэн дэвтэр энэ тэрээ авав. Тэрээр хатуу дэг журам, ёс горим, сахилга дүрэмтэй их хурлын танил уур амьсгалд дасаж эхэллээ. Энэ ёс дүрмийг сахих ч ёстой, тэр нь ч аятайхан байдаг билээ. Нөгөө өдөр тутмын, өчигдөрхөн хүртэл санаж сарвайж явсан юмаа умартан, сэтгэл зүрхийг түүнээс арай чухал, арай дээгүүр зиндааны бодол эзэмдэн, хуучин ангидаа буцаж ирсэн ахмад дайчин шиг сэтгэл дэвэлзэнэ.

Зочид буудалд түүнийг гурван хүний өрөөнд оруулав. Ор, шүүгээ хоёр байгаа хойно илүү юмны хэрэг байхгүй. Төлөөлөгчдийн дунд хуучин нөхөд нь олон бий гэдгийг Марк Александрович мэдэж байсан бөгөөд буудлын үүдний танхимд заримтай нь амжаад тааралдчихлаа. Сэтгэл хөдлөн баяр хөөртэй зогсож байгаа тэд нарыг хараад болж байгаа бүх юм зөв зүйтэй, бат найдвартай гэдэгт улам итгэн үнэмшив. Нам маань байна, намын боловсон хүчнүүд байна. Шалгарсан, хатуужсан, ажил явдлыг хааш нь яаж хөтлөхөө андахгүй ухаан задарсан боловсон хүчнүүд шүү дээ. Тэд нар Сталиныг дэмжиж байгаа нь гагцхүү тэдний хүч чадлыг л илтгэж байгаа хэрэг. Энэ үнэнч шударга, амь биеэ хайрладаггүй хүмүүс хэзээ ч хууль ёсыг зөрцүүлэхгүй. Сашад тохиолдсон явдал бол учир утгагүй зүйл. Тэрээр Сонягийн сүүлчийн захидлыг арав хоногийн өмнө авсан. Аягүй бол Сашаг тавьчихсан ч юм билүү?

Тэрээр эгч рүүгээ утасдав. Эгчийгээ дуугарахтайгаа зэрэг л юу ч өөрчлөгдөөгүй байна гэдгийг ойлголоо.

–Чи ирэх үү? гэж Софья Александровна асуув.

Тэрээр одоо Арбат руу явах дургүй байв. Оройтсоноос гадна унаа байхгүй, бас тэгээд хажуугийн өрөөнд найз нар нь хүлээж байгааг хэлэх үү. Гэтэл одоо явахгүй юм бол дараа хэзээ боломж гарах нь бүү мэд.

–Та унтчихгүй бол би цаг, цаг хагас хэртэй болоод танайд очъё.

–Би унтах биш дээ...

Марк Александрович эгчийндээ очсон биш урам нь хугарчихав. Эгч нь түүнийг царайчлан үглэж ямар нэгэн бичиг цаас уймран хайж тэр цааснуудаа чичирсэн хуруугаар толийлгон айх, горьдох хосолсон харцаар өөдөөс нь ширтэнэ. Тэрээр энэ мөчид эгчдээ дүү нь огт биш, харин хүүд нь тусалъя гэвэл туслах, үгүй гэвэл туслахгүй, аваръя гэвэл аврах, үгүй гэвэл аврахгүй энэ хорвоогийн эрхтэн дархтны нэг болж хувирчээ. Софья Александровна зовж зүдэрч байгаагаасаа болоод улам гярхай болсон тул дүү нь энэ хэрэг явдалд аягүйрхэж, бүхий л байдлыг цэгнэн үзэх санаатай байгааг нь ойлгов. Гэтэл өөрийнх нь хувьд гэвэл Саша нь шоронд орчихсон байхад цэгнээд байх юм юу байх вэ дээ.

Марк Александрович яах ч арга байхгүй хий дүлийрэн үүлгэртэж, хүзүү цээжээр нь хатгах шиг болов. Тэрээр Соняд ч хайртай, Сашад ч хайртай. Гэхдээ хий хоосон юм амлаж бас эс чадна. Өөрөө туршлагатай хүн. Коммунист хүн.

–Яг маргаашаас үүнийг чинь хөөцөлдье. Хэрвээ Саша ямар ч буруугүй бол түүнийг тавина.

Эгч нь түүнийг айж самгардсан харцаар ширтэв.

–Саша буруутай гэж үү... Тийм байж болно гэж чи бодож байна уу?

–Түүнийг ямар нэг юмаар буруутгаж байгаа л даа... Чухам юу гэж буруутгаж байгаа учрыг олохоос нааш би Москвагаас явахгүй.

Тэрээр эгчдээ тун хатуу үг хэллээ. Гэхдээ эгч нь юу ч сонсоход бэлэн байхгүй бол болохгүй. Эс тэгвээс дараа бүр хүнд цохилт амсана.

Марк Александрович Будягинтай бас уулзав. Нэр нь холбогдсон хүн одоо баривчлагдчихаад байгаа болохоор Будягин өөрөөс нь болж ийм ярвигтай байдалд хүрсэн хэрэг.

Тэрээр баргар царайлан их хурлын тухай нэг ч дурсахгүй ажлаа ердийн байдлаар гүйцэтгэж байв. Их хуралд сонгогдоогүйдээ гомдсон юм болов уу? Гэхдээ Төв Хороо, Төв шалган байцаах комиссын бусад олон гишүүний адил мань хүн ч мөн зөвлөх эрхтэй төлөөлөгч юм чинь энд гомдоод байх юм юу байх вэ, аль хэзээний л ийм журамтай шүү дээ. Магадгүй их хурал, түүний хувьд баяр ёслол биш улам хэцүү яршигтай ажил юм болов уу? Тэглээ ч гэсэн дээ... Ямар ч атугай өнөөдөр юм бодчихоод тун урамгүй, цаанаа л нэг ёозгүй царайтай байх ажээ.

–Та манай зээ дүүгийн тухай мэдэж байгаа билүү? гэж Марк Александрович асуулаа.

–Мэдэж байгаа.

–Тэгэхэд би танаас гуйхдаа ингэж эргэнэ чинээ даан ч бодоогүй шүү.

–Тэр ойлгомжтой хэмээн Будягин гомдол саналгүйгээр илэрхийлэн тайван өгүүлэв.

–Миний зээ дүү болохоор би байдлыг мэдэж авах эрхтэй хүн гэж Марк Александрович хэллээ.

Будягин дуугарсангүй. Тэрээр хоёр гараараа ширээ тохойлдон эрүүгээ тулаад Марк Александровичийг харах ажээ.

–Би их хурал дээр Ягода, Березин хоёрын аль нэгтэй ярихыг бодно хэмээн Марк Александрович Будягины илт дэмжихгүй буй энэ яриаг цэглэхээр шийдэв.

Гэтэл Будягин,

–Чиний зээ дүү гэдгийг тэд нар мэдэж байсан гэв.

Марк Александрович Будягин руу ширтэж,

–Энэ чинь юу гэсэн үг вэ? гэж асуув.

–Энэ явдалд чиний оролцож байгааг тэд ойлгож байсан. Үүнийг тэд бодолцсон гэснээ Будягин нэг л хачин харж – Сашагийн энэ бол тохиолдлын хэрэг биш гэж нэмж өгүүлэв.

Тэрээр саяынхыг өнгөрсөн удаа Черняк районы намын хорооны нарийн бичгийн даргаа хэдийн больсон гэж хэлсэн лүгээ адил өнгө аястай өгүүлэв. Харин түрүүчийн тэр зүйл мэдээлэл байсан бол одоогийнх нь яриагаа үргэлжлүүлье гэсэн санал байв.

Их хурал дээр ямар нэгэн юм болох гэж байгаа хэрэг үү? Юу байхсан билээ? Хэсэг, бүлэгт талцан хуваагдаж үзэл бодол нэгтэй буюу өөрийн талд санал өгөх хүмүүсийг хайж элсүүлэх хэрэг гарах нь уу? Удирдлагын дотор дахиад хагарал гарав уу? Түүнийг нь хэнээр солих гээ юм бол? Хуучин толгойлогч нар нэрээ нэгэнт барчихсан. Шинэ хүмүүс гарах нь уу? Чухам хэн бэ?... Ийм явдал балрах тавилантай, нам үүнийг дэмжихгүй, Сталин бол намын бодлого, намын чиг шугамын биелэл мөн.

Будягин тэр хоёр дэндүү нарийн юм ярьж байна. Санаагаа өчүүхэн төдий ч гэсэн дутуу орхиж, байр сууриа бүрхэгдүүлж хэрхэвч болохгүй, тэгж гэмээ нь тун төвөгтэй үр дагавар үүдэж мэднэ.

–Сашагийн баривчлагдсаныг цаанаа тийм гүнзгий учир агуулгатай гэж үзэх ёсгүй гэж би бодож байна. Тохиолдлын чанартай зүйлс бол ийм алсын дүгнэлт хийх үндэс болохгүй гэж Марк Александрович эрсхэн хэлэв.

–Тэрээр Будягиныг эвлэршгүй хурц харцаар шулуухан ширтэв. Тоогүй юм даа. Сайн коммунист, торойж тодорсон ажилчин, төрийн том зүтгэлтэн хүн гэх. Гэвч хилийн чанадад олон жил сууж, улс орноосоо хөндийрөн ард түмэн, нам юугаа хийж байгаа, нэг нөхөр нь болох Марк Александрович юугаа хийж байгааг мэдэхгүй болж дээ... Ер бусын эрин цагийн өмнө, энэ эрин цагийн шаардаж байгаа золионы өмнө балмагдан сандарч, ухран зайлж байгаа нь тэр.

–Нам сохор биш гэдгийг Иван Григорьевич, та надаас дутуугүй мэднэ шүү дээ.

Тэрээр Будягин руу харсан хэвээр. Түүний залуу нас, иргэний дайн энэ тэр гээд чухамхүү сэтгэлээс хэзээ ч гарахгүй эрхэм нандин зүйлс нь Будягинтай холбоотой. Гэхдээ одоо гол юм бол домна, мартен зуухны дөл гэрэлтсэн уулан дээр байгаа өөрийнх нь хот билээ. Энэ бол одоо хувьсгал. Хувьсгал үргэлжилсээр байна, Будягин бусад хүний адил түүнээс гарлаа ч гэсэн хувьсгал үргэлжилсээр л байх болно.

Марк Александрович Иван Григорьевичийг лав хариу хэлэхгүй нь гэж боджээ. Түүний одоо хэр хэлж чадах юм бол яль шальхан зүйл байх билээ. Чухам үүнээс болоод Будягины дуу тээр холоос сонсдох мэт бүдэгхэн дуулдаж мань хүн үгийг нь бараг ялгасангүй.

–Бид комсомолын гишүүдээ шоронд хийж байна гэж Будягин хэлжээ. Энэ үгсийн уй гашуу Марк Александровичийн ухамсарт ихээхэн хожуу хүрсэн...

... Кремлийн Их ордны үүдний танхимууд, дээшээ өгсөн гантиг чулуун өргөн шат, хурлын танхимын өмнөх тасалгаа энэ тэр цөм төлөөлөгчдөөр дүүрсэн байв. Тэдний зарим нь хэсэг бусгаар бөөгнөрч, зарим нь нааш цааш холхиж, зарим нь бас биеэ дуудаж, зарим нь хурлын материал олгож байгаа жижгэвтэр ширээнүүдийн дэргэд шавцгаана.

Марк Александрович ч мөн хурлын материалаас авлаа. Түүнийг бас хэдэн хүн дуудсан нь хуучин ажиллаж байсан Донбассынх нь танилууд ажээ. Дараа нь хонх жингэнэн дуугарч хүмүүс цөм танхим руу хөдөлцгөөв. Тэр танхимыг дээд талд нь зочдод зориулан тусгай том байр гарган өөрчлөн зассан тул хамаг юм нь шинэ оргин, мод будгийн үнэр хослон ханхална. Маргааш нь сонинд бичсэнчлэн “Танхим хуучнаа бодвол илүү ёсорхуу хэрнээ ер бусын сүрлэг даруухан болжээ. Хэдэн эрин үеийн хир буртаг гэлтэй алтадсан болхи тансаг байдал, багана, сүлд, элдэв одон тэмдэг сэлтийг хана туурганаас нь арилгасан нь танхимыг зайтай, гэгээтэй болгосон байна”

Тэдний төлөөлөгчдөд дөрөв, тавдугаар эгнээнд яг индрийн өөдөөс харсан суудлууд таарчээ. Индрийн ойролцоо Каганович, Оржоникизе, Ворошилов, Косиор, Постышев, Микоян, Максим Горький нар зогсож байв. Калинин шатан дээр суугаад, төмөр хүрээтэй хөдөөгийн шилээрээ танхим руу байн байн харж, тэмдэглэлийнхээ дэвтэрт нэг юм түргэн түргэн бичнэ.

Молотовыг тэргүүлэгчдийн ширээнд ирэхэд төлөөлөгчид алга ташин угтсанаа Сталиныг хажуугийн хаалгаар гарч ирмэгц дахин их сүртэй нижигнүүлэн ташицгаав. Алга ташилт улам хүчтэй нижигнэж, сандал түр торхийх дуутай хослон бүх хүн босоцгооход дээд талаас “Нөхөр Сталин мандтугай! Ура!...” гэж нэгэнтээ хашгирлаа. Тэр даруйд бүх хүн “Ура! Большевизмын аугаа их штаб мандтугай! Ура! Дэлхийн пролетарийн аугаа их удирдагч мандтугай! Ура! Ура! Ура!” хэмээн хашгиралдав.

Сталинд зориулсан ура хэд дахин давгагдав... Молотов түүний нэрийг нэрлэмэгц “Манай ялалтыг зохион байгуулагч бөгөөд жолоодогч нөхөр Сталиныг хүрээлэн...” гэхчлэн хашгиралдсан. Молотовын үгийн төгсгөлд... “Нөхөр Сталинаар толгойлуулан шинэ шинэ ялалт өөд урагшаа...” Дараа нь Хрущёв тэргүүлэгчдийн нэр дэвшүүлэхэд... Тэгээд эцэст нь хурлын дарга “Нөхөр Сталин үг хэлнэ” гэж зарлахад хамгийн сүртэй хашгиралдаан болов.

Марк Александрович бусдын нэгэн адил босоход нь босож, алга ташихад нь ташиж, “ура!”

хашгирахад нь хашгирч байлаа. Сталин бусад тэргүүлэгчийг бодвол нэлээд цайвар өнгийн цэрэг цамцтай байх бөгөөд индэр дээр ура хашгирах намдахыг тайван хүлээж цаасаа янзлан зогсоно. Тэрээр энэ алга ташилт, энэ уухайг өөртөө хамааруулж үзэхгүй, харин улс орон, намын их ялалтыг төлөөлөх ямар нэгэн хийсвэр Сталинд хамааруулж, тэгээд өөрөө тэр Сталиндаа бас алга ташиж байх шиг санагдана. Сталин үүнийг ойлгож байгаа төдийгүй илтгэлдээ “Нөхөр Сталинд бид мэндчилгээ дэвшүүлээ биз дээ, бид түүнээс илүү яах юм бэ” гэж ёж үг хүртэл оруулсан нь Сталин болон түүнийг ийнхүү баяр бахдал болон мэндчилж байгаа хүмүүсийн хооронд бие биеэ ойлгосон ойр дотно харьцаа байгаа мэт бодогдуулна.

–Арван тавдугаар их хурал дээр хэмээн Сталин үгээ эхэлж –намын бодлогын зөвийг нотлох, Лениний эсрэг тодорхой бүлэглэлүүдтэй тэмцэл явуулах шаардлагатай байсан бол... энэ их хурал дээр хэмээн Сталин үгээ эхэлж – энэ их хурал нотлоод байх ч юмгүй, бас тэгээд цохиод байх ч хүнгүй байх шив. Намын чиг шугам ялсныг цөмөөрөө харж байна гэлээ.

Энэ үгс Марк Александровичийн их хурал тайван болж өнгөрнө, Ломиназегээс болж элдэв төвөг үүдэхгүй гэсэн таамаглалыг нотлов. Сталин эв нэгдэлтэй байхыг өөрөө хүсэж байна. Тэмцэл дууслаа тэгэхлээр түүнтэй холбогдсон нэг бол сайн, нэг бол муу гэж хэтрүүлдэг явдал ч арилах ёстой. Бас энэ нэг маягийн уухай урианууд ч үгүй болох ёстой. Марк Александровичийн иймэрхүү бодлыг Сталин төгсгөлийн үг хэлэхээс татгалзсан явдал бас нотлох шиг санагдав.

–Нөхөд өө! Их хурал дээр гарсан санал шүүмжлэл манай намын удирдагчдын үзэл бодол, намын бодлогын бүх асуудлаар гэж хэлсэн ч болно, яв цав нэгдмэл байгааг харууллаа. Тайван илтгэлийг эсэргүүцсэн зүйл юу ч байгаагүйг та бүхэн мэдэж байна. Ингэхлээр манай намын эгнээний улс төр - үзэл суртал, зохион байгуулалтын ер бусын бат нягтрал тодрон илэрлээ. Ийм байхад төгсгөлийн үг хэлэх шаардлага байна уу? гэдэг асуулт гарч байна. Би бол тийм шаардлага алга гэж бодож байна. Ийм учраас төгсгөлийн үг хэлэхгүй байхыг зөвшөөрөн болгооно уу...

Ломиназе бараг шууд Сталины илтгэлийн дараа үг хэлж, дараагаар нь Рыков, Бухарин, Томский, Зиновьев, Каменев, Пятаков, Преображенский, Радек гээд эсрэг бүлэгт байсан бусад хүн үг хэлэв. Тэд арван зургадугаар их хурал дээрх шиг гэмшиж нахилзаагүй, харин алдаагаа ажил хэрэгчээр задлан шинжилж, дуу хоолойгоо намын дуу хоолойтой нийлүүлжээ. Тэдний үгийг хэн ч тасдаагүй, хэн ч илүү юм хэлэхийг шаардаагүй, хэн ч тэдний хэлснийг чамлаагүй. Гагцхүү Рыковт ганц удаа “Цагаа баримтлаарай!” хэмээн тэсэлгүй хэлжээ.

Пятаков Төв Хорооны бүрэлдэхүүнд, Рыков, Бухарин, Томский, Сокольников дөрөв орлогч гишүүнд нэр дэвшсэн. Төв Хорооны шинэ бүрэлдэхүүний жагсаалттай санал хураахаар тараасан хуудас их хурал болгон дээр удирдлагад хэн нэг нь орж, хэн нэг нь гардаг зүй ёсны өөрчлөлттэй байдаг хуучин хуудастай бараг адилхан байлаа. Марк Александрович нэрсийн жагсаалтаас өөрийнхөө нэрийг ч бас олж үзлээ. Тэрээр Төв Хорооны орлогч гишүүнд нэр дэвшжээ. Үүнийг мань хүн хоёрдугаар таван жилд тэдний үйлдвэрийн гүйцэтгэх үүргийг үнэлж байгаагийн илрэл гэж ойлгов. Бусад томоохон барилга байгууламжийн дарга нар, томоохон үйлдвэрүүдийн захирлын нэрийг ч нэрсийн жагсаалтаас олж үзлээ. Энэ бол цаг үеийн шинж, улс орныг үйлдвэржүүлж байгаагийн шинж даруй мөн.

Будягины нэр жагсаалтад алга.

Гэтэл Саша Будягиныхаар бишгүй орж гардаг байсан. Иван Григорьевич түүнийг байхад элдэв юм ярьдаг байсан болов уу? Лениний захиаг мань хүн түүнд өгч уншуулаагүй байгаа? Зөвхөн ярианд оруулаад ч зогсоогүй юм биш биз?...

Марк Александрович Ягода, Березин хоёрын алиныг ч танихгүй. Гэхдээ Улс төрийн ерөнхий газрын дарга Ягодатай ярилцана гэхэд Сашагийн хэргийн ач холбогдол түүний зиндаанд дүйхгүй юм. Түүнээс гадна тэр баргар царайтай зожиг хүн өөрт нь нэг л аягүй санагдана. Харин Березин яг ийм хэрэг явдлыг хариуцдаг учраас түүнтэй ярилцахад зүй ёсны хэрэг. Гэтэл хурлын завсарлагаанаар Марк Александровичийг хэн нэг хүн тааралдаад саатуулчихна, эсвэл Березин өөрөө нэг тийш алга болчихоод олдож өгөхгүй байлаа. Нэгдүгээр сарын гучин нэгэнд Арван долдугаар их хуралд зориулсан хөдөлмөрчдийн жагсаалын үеэр сая нэг аятайхан боломж гарав.

Марк Александрович элдэв жагсаал үзсэн нь цөөнгүй боловч энэ удаагийнх хамгийн сүртэй байв. Хоёр цаг гаруйхны хооронд Улаан талбай дээгүүр сая гаруй хүн явж өнгөрлөө. Нэгдүгээр сарын жаварт, харанхуй дотор хурц чийдэнгийн гэрэлд яваа жагсаал улам ч сүр бараатай харагдах аж.

“Сталин!” Жагсаалын бүх ухуулах самбар, уриа энэ тэр дээр бичсэн цорын ганц энэ үгийг хүмүүс хоолой нийлүүлэн хашгирч, энэ үг жавартай агаарт царцан тогтсон мэт санагдах агаад бүх хүний харц шинель өмсөөд энгийн үстэй малгайныхаа чихийг буулгаад зогсож байгаа Сталины зүг, Мавзолейн индэр рүү чиглэжээ. Индэр дээр байгаа хүмүүс цөм дулаан малгайтай байгаа боловч гагцхүү Сталин л малгайныхаа чихийг буулгасан нь түүний даарч байгааг илтгэхийн сацуу адилхан даарч байгаа энэ түм түмэн хүнд түүнийг улам энгийн даруу, хүнлэг дүртэй харагдуулна. Сталин тэднийг мэндчилэх гэж Мавзолейн индэр дээр хэдэн цагаар хөдөлгөөнгүй зогсож байгаа юм чинь энэ явж байгаа улсаас илүү ч даарч байгаа шүү дээ, хөөрхий.

Марк Александрович их хурлын бусад төлөөлөгчийн хамт Кремлийн ханын дагуух индэр дээр зогсож байв. Өөрийнхөө барилга дээр энэ байтугай жаварт дассан боловч шаахайтай ирсэн учир хөл нь даараад болдоггүй, эсгий гуталтай л ирдэг байж дээ. Тэрээр Березинийг олж бараадасхийн зогссоноо цуглаан дуусаж жагсаал эхэлмэгц түүн рүү очив.

Березиний цаатан маягийн хүрэл царай гагцхүү аврах, алах асуудал л сонсож байдаг хүний тэнсэн азнах дүрийг оллоо. Гэвч их хурлын төлөөлөгч хүн ирж буйг үзээд эелдэгхэн толгой дохисноо, Рязановыг нэрээ хэлмэгц бүр өөриймсөг мэндчилэв. Марк Александрович Сашагийн явдлыг товчхон танилцуулж, нөгөө ханын сонин, Сольц хоёрын тухай дурсаад, зээ нь шударга бусаар яллуулснаасаа болоод залуу насныхаа аагаар ярих ёсгүй ямар нэгэн юм хэлсэн байж болох талтай ч түүний ямар ч буруугүй гэдгийг биеэрээ нотолно гэж хэллээ. Тэгээд хэрэв Саша өөр хэргийн учир баривчлагдсан бол дүүгийнх нь хэрэг өөрт нь хамаагүй байх ёсгүй учир тодорхой мэдээлэхийг хүсэв. Березин талбай дээр явж буй жагсаал руу хаа нэгтээ харах зуур Рязановын ярьсныг анхааралтай сонслоо. Жагсаал руу харах үед түүний нүүрэнд хурц гэрэл тусаж, сэлхэрч үлхийсэн царайд нь ядарсан байдал илт мэдэгдэнэ. Тэрээр Марк Александровичаас Сашагийн овгийг дахин асууснаас өөр юу ч дуугарсангүй,

түүний хэрэг явдлын тухай мэдээлэхийг хүссэний хариуд “Тэрбээр гүн харанхуйд нуугдан буй...” хэмээн инээмсэглэн өгүүлсэн нь энэ явдлын тухай өөрөө юу ч мэдэхгүй, мэддэг байлаа ч гэсэн тэр тухай ярьдаг газар, хэлцдэг цаг биш, тэр ч байтугай боломжийн газар байлаа ч гэсэн мань хүн тэртэй тэргүй ямар нэг юм хэлж чадахгүй, ерөөсөө л ийм ажилтай улс гэдгийг ойлгуулсан хэрэг аж.

–Би тэр хэрэгтэй танилцамз, тэгээд бололцоотой бүхнийг хийнэ. Мөрдлөг үнэн зөв, хянуур нямбай явагдах болно.

Марк Александровичид энэ хариу нухацтай, горьдлоготой, чин сэтгэлийн үгс шиг санагджээ. Мань хүн тийнхүү сэтгэл амарч Березинээс холдов.

Марк Александрович Сольцтой бас ярилцах бодолтой байжээ. Гэтэл Сольц өвчтэй учраас их хурал дээр байсангүй. Өвчтэй хүнтэй гэрт нь очиж уулзахыг Марк Александрович эвгүй гэж бодохын зэрэгцээ Березинтэй ярьчихсаны дараа тэгж явахын хэрэгцээ ч алга гэж үзжээ.

Москвагийнхан мавзолей дээр зогсож байгаа Сталинд баяр талархлаа дэвшүүлэн, олон хүчтэй чийдэн тусгасан Улаан талбай дээгүүр жагсан явж байхад Бутырын шоронд оройн хоолны цаг болов. Хонгилд эсгий гутлын зөөлөн чимээ гарснаа цоож хяхтнах, төмөр тавгаа халбагаар тогшлох, сэнжтэй аяганд буцалсан ус хийх чимээ сонсогдлоо. Шагайвчийн дугариг таглааг хажуу тийш болгоход хоромхон зуур бяцхан нүхээр гэрэл туссанаа хянагчийн толгойд хаагдан алга болов. Хянагч өрөөг шалган харснаа шагайвчийн таглааг буулгаад хаалганы бяцхан цонхыг онгойлгож,

–Оройн хоол! гэв.

Саша төмөр тавгаа сарвайлаа. Хоол түгээгч нэг эрүүгийн хэрэгтэн өөр нэг ялтан туслагч хоёр гардан барьж яваа савтай агшаасан будаанаасаа нэг халбагдаж түүний таваг руу хийгээд, данхтай буцалсан уснаасаа сэнжтэй аяганд нь аягалж өгөв. Хянагч тэр хооронд Саша хоол түгээгчид юм дамжуулах вий, хоол түгээгч хоёр Саша руу харах вий гэж хянаж байв.

Энэ хонгилын хэсэгт улс төрийн хэрэгтнүүд хоригдож байгаа ажээ. Тэд нар мөн л цонх руугаа очиж таваг, аягаа сарвайн агшаасан будаа, буцалгасан усаа хийлгэж авна.

Энэ хүмүүс хэн хэн бэ? Хоёр долоо хоноход Саша хоол түгээгчдээс өөр хоёрхон ялтныг харж амжжээ. Нэг нь үсчин гэгдэх яргачны хүйтэн харцтай, нарийхан магнайтай, шонтгор эрүүтэй үлхгэр өвгөн. Тэрээр гойд мохоо хутгаар сахал хусаж өгнө. Саша сахлаа ургуулахаар шийдээд дахин түүн дээр очоогүй. Нөгөөдөх нь энгэсэгтэй эм шиг царайтай эрүүгийн хэрэгтэн залуу. Тэрээр хонгил цэвэрлэж байснаа Сашаг түүгээр тууж өнгөрөх үед хана руу хараад зогсчихсон нь явж байгаа хоригдлыг ч харах эрхгүй, түүнд ч өөрийнхөө царайг харуулах эрхгүйн учир тэгсэн хэрэг аж. Тэглээ ч гэсэн өөр рүү нь сониучирхсан төдийгүй сэргэлэн янзтай хялайн харсныг Саша мэдэрчээ.

Сашаг салхинд гаргах буюу жорлонд аваачихад бүх өрөө үхмэл мэт чимээгүй байх шиг санагддаг аж. Гэвч анхны үдэш оройн хоолны дараа баруун гар талын ханынх нь цаанаас аяархан тогших сонсогджээ. Ойрхон ойрхон зөөлөн тогшилсноо жаахан азнасхийгээд ханан дээгүүр нэг юмаар зурж байх шиг шурхийв. Дараа нь хөрш нь хариу хүлээв бололтой чив чимээгүй болчихов. Саша ийм дохиогоор харилцаж чаддаггүй болохоор хариу өгсөнгүй. Маргааш нь бас оройн хоолны дараа тогших чимээ дахин гарчээ.

Саша хөршийгөө сонсож байна гэдгийгээ ойлгуулахын тулд нугалсан хурууныхаа үеэр хана руу хэд тогшлов. Түүнээс хойш орой бүр ингэх болжээ. Гэхдээ хөрш нь юу гээд байгаагийн учрыг тэрээр тайлж чадсангүй. Уул нь эхэлж хэд тогшсоноо түр азнасхийж дахин хэд тогшоод эцэст нь шурхийн зурах чимээ гараад байна гэдгийг ухаарсан аж. Саша хөршийнхөө юу хэлэх гээд байгааг ойлгохгүй байлаа ч гэсэн шоронгийн хүний горьдлого бялхсан энэ болгоомжтой дохионд сэтгэл догдлох болжээ.

Сашагийн зүүн гар талын хананаас дохио гараагүй төдийгүй өөрийнх нь тогшилтод ч хариу өгөөгүй аж.

Саша агшаасан будаагаа идэж гүйцээд халбагаа долоож, цайны ханд, ёотонгоо сэнжтэй аягатай ус руугаа хийж халбагаараа хутган зөөг цайгаа уучихаад босож өрөөн дотуураа нааш цааш нэгэнтээ алхав. Мухрын хананаас үүд хүртэл зургаан алхам, нэг булангаас нөгөө булан хүртэл өрөөлдөөд мөн зургаан алхам. Энэ нь гипотенуз нь катетаасаа урт байх ёстой гэдэг геометрийн хуулийг зөрчиж байгаа хэрэг боловч үнэндээ тэр хоёрын ялгаа нь мэдэгдэхийн аргагүй өчүүхэн байж. Өрөөний нэг буланд нь хөтөвч хувин, нөгөөдөхөд нь ор, гурав дахид нь бяцхан ширээ байрлуулж, дөрөв дэх нь хоосон байна. Таазанд төмөр тортой бүдэгхэн гэрэл байна. Таазнаас доохно зузаан хананд зөндөө налуулж гаргасан гүн гонхонд бүдүүн төмөр торны цаана бохиртсон жижигхэн шилэн цонхтой.

Үдээсгүй шаахай нь алхах тоолонд сугаран бетон шалыг алгадна. Тэлээгүй өмднийхөө захны шилбийг мөрөвч тогтоох товчноос товчилж аргацаажээ. Тэгэхлээр өмд нь жиширчихээд хөдлөхөд эвгүй ч гэсэн шувтарч унахын зовлон эдлэхгүй дажгүй байна.

Сашаг ийш тийш нь дуудахгүй, мөрдөж байцаах ч үгүй, ял хэрэг ч тулгахгүй өдий хүрлээ. Тэрээр тодорхой хугацааны дотор хэрэг тулгах ёстой гэдгийг мэдэх билээ. Гэхдээ чухам ямар хугацаа байдгийг мэдэхгүйн гадна мэдэх ч аргагүй байв.

Заримдаа өөрийнх нь тухай мартчихсан, тэгээд энд үүрд булагдсан мэт бодогдоно. Тэрээр ийм юм бодохгүйг хичээн түгшүүр айдсыг үлдэн хөөхийг оролдоно. Хүлээх хэрэгтэй. Дуудах цагтаа дуудаж, байцаах юмаа байцааж, бүх юмны учир олдоод түүнийг суллах болно.

Тэрээр гэртээ хэрхэн эргэж харихаа төсөөлөн бодно. Хонхоо дарна... Үгүй ээ, дэндүү санамсаргүй хэрэг болно. Тэгэхлээр “Саша удахгүй очно” гэж утсаар урьдчилж мэдэгдчихээд тавиад хүрчихнэ. “Ээж ээ, сайн байна уу, би байнаа...”

Ээжийнхээ зовж байгааг бодохоос тэсэхүйеэ бэрх. Магадгүй, чухам хаа байгааг нь мэдэхгүй, айж мэгдсэн өчүүхэн амьтан шорон шоронгийн хооронд хэсүүчлэн эцэс төгсгөлгүй цуваанд арга барагдан зогссоор байж ч мэднэ. Бүх юм мартагтана. Гэхдээ ээж нь бол юуг ч мартаж чадахгүй, энэ дайрлагыг давж ухаан орох нь өнгөрсөн. Тэгж бодохоос л энэ шоронгийн ханыг мөргөж, төмөр хаалгыг сэгсчиж, орь дуу тавьж, нударгалдмаар санагдана...

Цоож хяхтнаад хаалга онгойлоо.

–Бие зас!

Саша нүүр гарынхаа алчуурыг мөрөн дээрээ тохож, хөтөвч хувингаа аваад хянагчийн түрүүнд орж хонгилоор сажлав.

Жорлонгийн хлорын шохой өрөөнийхөөс бүр ч хүчтэй ханхална. Саша хувингаа зайлж асгаад хлорын уусмалаар шүршив. Хувингаа хөтөвч болгож бараг хэрэглэдэггүй ч гэсэн үнэр заавал байх. Дараа нь буцаж ирвээс төмөр хаалга торхийн хаагдаж, ингээд маргааш өглөө болтол дахин онгойхгүй болох нь тэр.

Таазны доохонтойх цонхны булингатай шилний цаана оддын гэгээ тасраагүй байхад хонгилд дахин хөлийн чимээ сонсдоно. Мань хүний хаалганы түгжээ ч бас хяхтнана.

–Бие зас!

Шоронгийн ердийн өдөр эхлэх нь энэ. Хаалганы шагайвчийн таглааг эргүүлж, цонхыг онгойлголоо.

–Өглөөний хоол!

Хоол түгээгчийн энгэртээ өлгөсөн сарампай тавиур дээр хэрчсэн хар талх, хэсэг ёотон, цай, давс, дундуур нь тасалсан хайрцагтай “Бокс” тамхи, шүдэнз, шүдэнзний хайрцгийн зуруулын өөдөснүүд байна. Сашагийн аз дайрчээ. Өдөрт найман ширхэг папирос өгдөг атал нэг хайрцагтаа хорин тав байдаг билээ. Гурав дахид нь таарсан хүн есөн ширхэг тамхи, хайрцгийн тасархайтай цуг авна. Энэ картоны өөдөс бол, муу хэлээд яах вэ, ямар ч байсан цаас шүү дээ. Тэгтэл өнөөдөр энэ өөдөс Сашад таарчихлаа. Гадагш нь зурвас бичихэд хэрэг болох ч юм билүү. Тэрээр энэ өөдсөө хаашаа хийхээ мэдэхгүй, дэмий л хаалганы батарейн араар хавчуулав.

Зах нь хуурч унасан хөөлт муутай зуунгитсан талх өгдөг ч гэсэн тэр нь өглөөгүүр жинхэнэ талхны шинэхэн исгэлэн үнэрээр ханхална. Энэ үнэрээс болж аавынх нь ажлын газраас талхны оронд хагас жилийн нормонд өгсөн гурилыг ээж нь талх бариулахаар өгсөн дээр үеийн нэг явдлыг Саша санав. Тэгэхэд талхны газраас тушаасан гурилаасаа илүү их талх буцааж авсан бөгөөд энэ шидтэй илүүдэл ой тойнд нь удтал эргэлдэн байж билээ. Тэрээр ээжтэйгээ хоёулаа талхаа чарган дээр аваад явж байсан тэр нэгэн өлөн зэлмэн өвөл, мөстсөн цасан дээгүүр шажигнан гулгаж агсан төмөрлөсөн ултай чарга, шинэхэн барьсан талхны бүлээхэн амьсгал, талхаа хэрчиж хатаагаад өвлийг давна хэмээсэн ээжийн баяр хөөр энэ тэр одоо талхны зах хазлан цай ууж байхад сэтгэлд орж ирдэг байгаа даа. Тэгвээс зүрх нь гөхөлзөн шимшрээд ирлээ. Хүүхэд ахуй цагийн энэ гэгээн дурсамж энэ шоронгийн хувьд, чухам юуны учир хоригдсоноо мэдэхгүй буй энэ харанхуй өрөөний хувьд дэндүү хүнлэг нандин дурсамж ажээ.

Түгжээс нь тар нярхийн хаалга онгойход винтов барьсан, дахтай харгалзагч үүдэнд зогсож байв.

–Салхинд гар!

Хувцаслаж өрөөнөөс гараад зүүн гар тийш эргэн хонгилын ам хүртэл явж, хашаа руу гарах хаалгыг сайхь харгалзагч онгойлготол хүлээнэ. Дараа мөн л тэр замаараа, нөгөө л хаалгаа онгойлгож түгжсээр буцаж ирнэ. Энэ бүхэн салхинд гарахтайгаа нийлээд хорин минут.

Салхинд гардаг жижигхэн дөрвөлжин талбай хоёр талаасаа шоронгийн байшингаар, гурав дахь талаасаа туйпуугаар барьсан дугуй цамхгаар хашаастай. Энэ цамхгийг Пугачёвын цамхаг гэдгийг Саша хожим мэдэж авчээ. Саша цасан дундуур дагтаршсан тойрог зөргөөр явдаг байв. Зарим хоригдол тойргоор явахын оронд нэг булангаас нөгөө рүү өрөөлдөж явах нь дээр гэж үздэг учир хашаан дотуур чигээрээ зөргүүд бас бий. Харгалзагч буугаа барьсан чигээрээ шоронгийн үүдний хатавчийг налан зогсох зуур заримдаа тамхиа татаж, заримдаа Саша руу нүдээ онийлгон харна.

Дагтаршсан цас хөл дор хяхарна... Орой дээрх хөх тэнгэр, хаварт анивалзсан цэнхэр одод, тэртээх гудамжны чимээ, шатаж байгаа нүүрс болон утааны үнэр энэ тэрд Саша сэтгэл хөдлөн дотор бачимдана. Шоронгийн өрөөнүүдийн цонх гэрэлтэй буй нь Саша энд ганцаар бус гэдгийг гэрчилнэ. Шоронгийн үнэр танартай бүгчим тасалгаанаас гарсан хүн цэнгэг агаарт мансуурна. Шоронгийн амьдрал ч гэсэн бас л нэг амьдрал, хүн амьсгалаа хураагаагүй байгаа цагт амьдрал үргэлжилж, найдлага горьдлого үл тасрах агаад хорин хоёр насанд бол бүх амьдрал тэр чигээрээ найдвар.

Харгалзагч хатавчнаас хөндийрөн бугаараа тогшилж, хоёр дахь хаалгыг онгойлгоно.

–Ороорой!

Саша тойргоо гүйцээж бяцхан хашааг орхин буцна. Тэд дахин шатаар өгсөж, дахин түлхүүр харжигнаж, өрөөний хаалга хаагдахуйд дахиад л нүцгэн хана, өнчин ор, бяцхан ширээ, хөтөвч хувин, хаалганы шагайвч энэ тэр хүрээлээд авна. Гэвч бие сэргээсэн цэнгэг агаар, гадаа сонссон тэртээх гудамжны чимээ хоёр нэг хэсэгтээ сэтгэлд хань болж, Саша тун саяхан дээр нь мэлтийж байсан цэнхэр тэнгэрийн өчүүхэн хэсгийг онигор цонхоор ширтэн харж зогсох авай.

Бас нэг сэтгэл баясгадаг юм нь шүршүүрийн халуун ус. Долоо хоногт нэг удаа шөнийн цагаар тийш нь аваачна. Хаалга онгойгоод харгалзагч,

–Усанд ороод удаж байна уу? хэмээн Сашаг сэрээнэ.

–Удаж байна.

–Тэгвэл явна аа!

Саша босон харайж бушуухан хувцаслаад нүүр гарын алчуураа авч өрөөнөөс гарна. Халуун усны үүдний өрөөнд нөгөө харгалзагч түүнд бор савангийн өөдөс өгөхүйд Саша цаашаа яваад орчих нь тэр. Усны халуун, хүйтнийг тохируулах юм байхгүй тул нэг бол халуун, нэг бол хүйтэн ус гоожно. Саша шүршүүрийн дор буянаа эдлэх мэт дуу дуулан зогсоно. Усны шуугианд дуу нь цохигдоод үүдний өрөөний цонхны тавцан дээр сууж байгаа харгалзагчид сонсогдохгүй байх шиг Сашад санагдана. Харахад хөгжүүн, дуулгавартай байрын царайтай энэ улаан цэрэг түүнийг огт яаралгүйхэн тайван сууж байх нь хэнийг хүлээж суух нь ямар ялгаа байхсан билээ, үүнийг биш гэхэд нөгөө нэгийг нь сахиад л сууж байх шүү дээ гэсэн мэт. Саша биеэ зөндөө удаан угааж нөгөө савангийн өөдөс зөөлрөн үзэх төдий юм үлдсэн боловч мань хүн ууц, гэдэс, хөлөө ээлжлэн шүршүүлж, усан дор зогссоор байв... “Хонх жингэнэсэн гурвал морьт тэргээр давхиулж явлаа, холын алсад галын гэгээ жирэлзэн байлаа... Үүнээс хойш хэзээ та нартайгаа учирч, үймэрсэн сэтгэлийн гунигаа тайлахсан бол, хөөрхий...”

Тэрээр үүдний өрөө рүү гарч ирээд биеэ арчиж байхад харгалзагч цэрэг ийм залуухан, харваас боловсролтой энэ хөвгүүнийг чухам юуны учир энд байлгаад байгааг ойлгож ядсандаа ч тэр юм уу, эсвэл Сашагийн булчин шөрмөс сайтай бие бялдрыг бахарханда ч тэр юм уу, их л сониучирхан харж суулаа.

Нэг шөнө харгалзагч,

–Усанд ороод удаж байна уу? хэмээн нөгөө л асуултаа асууж түүнийг сэрээв.

Саша урьд шөнө нь усанд орсон юм чинь мань харгалзагч будилсан бололтой.

–Удаж байна.

–Тэгвэл явна аа!

Саша усанд ороод биеэ арчиж байх зуураа,

–Ойрхон ойрхон орж байвал сайнсан... гэж өгүүлэв.

Жижигхэн харгалзагч ямар ч хариу хэлээгүй боловч хойт шөнө нь бас түүн дээр хүрээд иржээ. Саша бараг шөнө болгон усанд ордог боллоо. Заримдаа унтмаар санагдаж босох дургүй байвч, энэ удаа үгүй гэчихвэл тэр харгалзагч дараагийн шөнө ирэхээ болчихно. Ер нь яагаад ингэж өөрт нь талтай хандаж байна вэ? Бусад нь шөнө усанд орохоос дургүйцдэг, тэгээд энэ харгалзагч уйддаг байж болох юм. Юм хямгадаж сурсан тариачны хөвгүүнд ус хий гоожоод байх нь хайран байж болох л доо. Эсвэл өөрийнх нь хариуцдаг шүршүүрийг Саша үнэлж байна хэмээн түүнд талтай байгаа ч байж мэдэх юм.

Цоож хяхтнах чимээгээр Саша сэрэв. Харгалзагч өрөөнд нь орж ирлээ. Гэхдээ нөгөө шүршүүрт аваачдаг биш, бүсэндээ тоогүй олон түлхүүр зүүсэн өөр нэг үл таних харгалзагч ажээ. Хянагч үүдэнд зогсоод,

–Овог?

–Панкратов.

–Хувцасла.

Саша орноосоо босов... Хааш нь аваачих нь вэ?... Суллаж байна уу?... Шөнө сулладаг нь ч юу билээ? Ер нь цаг хэд болж байгаа бол?

Тэрээр пальтогоо өмсөх гэв.

–Хэрэггүй!

Харгалзагч баруун гар тийш эргэж явахыг толгой дохиж тушаагаад өөрөө араас нь дагав. Бүсэнд нь түлхүүр хангинана. Тэр хоёр төмөр тороор бүрсэн шатны хажуугаар огцом огцом хонгилоор зөндөө удаан явлаа. Ээлжит хонгилын төмөр хаалгыг нээхийн өмнө харгалзагч түлхүүрээрээ тогшино. Цаад талаас нь яг тийнхүү төмөр тогших хариу сонсдоно. Гагцхүү ингэсний дараа л хаалгыг түлхүүрдэн онгойлгох ажээ.

Саша шоронгийн аль хэсэг рүү явж байгаагаа чиглэлээрээ баримжаалахыг оролдон харгалзагчийн урд явж байв. Тэр хоёр шатаар нэг өгсөж, нэг уруудсаар мань хүний

тооцоолсноор нэгдүгээр давхарт ирэх шиг болов.

Эндэх олон хаалга төмөр биш ердийн модон бөгөөд цонх, шагайвч энэ тэргүй ажээ.
Харгалзагч нэг хаалгыг тогшив.

–Ороорой!

Хурц гэрэлд Саша нүд гялбав. Ширээний цаана сууж байсан хүн чийдэнгээ эргүүлж яг түүний нүүр рүү тусгажээ. Саша нарийн хурц гэрэлд нүд гялбан хаашаа явах, юу хийхээ мэдэхгүй зогсов.

Чийдэн доошилж ширээ, ард нь суугаа хүн хоёр дээр гэрэл туслаа.

–Суугаарай!

Саша суулаа. Түүний өмнө эвэр хүрээтэй том шилтэй, цайвар хонгор үстэй, ахмад цолтой, бие давжаа мөрдөн байцаагч сууж байлаа. Хэрвээ түүнийг цэрэг хувцасгүй байна гэж санах юм бол Сашагийн нүдэнд танил, сэтгэлд дасал болсон хөдөөгийн комсомолын идэвхтэн буюу тосгоны багшийн дүр яг мөн дөө. Ширээн дээрх маягтыг мөрдөн байцаагч бөглөж эхлэв... Овог?... Нэр?... Төрсөн он?... Төрсөн газар?... Хаяг?...

–Гарын үсгээ зураарай!

Саша гарын үсгээ зурлаа. Тэр маягтад мөрдөн байцаагчийн овог Дьяков хэмээн бас бичээтэй байв. Тэрээр үзгээ бэхний сав ирмэгдүүлж тавиад Саша руу эгцлэн харав.

–Та юуны учир энд хоригдож байна?

Саша ийм юм асууна гэж даанч бодсонгүй.

–Таныг л надад хэлж өгөх юм гэж бодож байлаа.

Дьяков гэдэсхийн сандлынхаа аравчийг налав.

–Та тоглоом тохуу хийхээ больж үзээрэй! Хаа байгаагаа мартаж болохгүй шүү. Энд бол би асууж, та хариулах ёстой. Тийм ч учраас би танаас юуны учир баригдсан бэ? гэж асууж байна.

Тэрээр үүнийг хэлэхдээ Сашаг өөр хэн нэгэн хүн баривчилсан байтал мань Дьяков ингэж учрыг нь олох хэрэг болж байгаа юм шиг царайлан, тэгэхлээр Саша чухам юуны учир баригдсанаа мэдэхгүй байх ёс байхгүй, тийм учраас цаг хий үрэхийн хэрэг алга, хэрэг явдлын учрыг тэр хоёр хичнээн түргэн олно төчнөөн сайн болно гэх маягтай байв. Өрөөнд харанхуй байна. Чийдэн гагцхүү ширээг л гэрэлтүүлж Дьяков арагшаа сандлаа налахад нүүр нь гэрлээс алга болж, дуу нь харанхуйгаас сонсогдох ажээ.

–Сургууль дээр болсон явдал юм болов уу даа гэж Саша хэллээ.

–Юун явдал билээ? хэмээн Дьяков энэ тухай аль хэдийн мэдэх, энэ явдал Сашаг

баривчилсантай ямар ч холбоогүй мэт тоомжиргүй лавлав. Ямар ч ашиггүй ингэж цааргалахаас бүр залхаж гүйцсэн боловч мөрдөгдөж байгаа бүх хүн иймэрхүү янзаар эхэлдэг тул энэ бүхнийг сонсохоос зайлах арга байхгүй.

Мэх үү? Эсвэл энэ мөрдөн байцаагч үнэхээр юу ч мэдэхгүй юм болов уу?

Бүх юм Сашагийн урьдчилан таамаглаж, биеэ бэлтгэж байснаас шал өөрөөр өрнөж байна. Тэрээр бага байхдаа нэг удаа галын шатаар байшингийн дээвэр дээр гарах гэж авирч байтал шатны дээд талын бэхэлгээний төмөр саваа тасарчихсан шатны үзүүр ганхаж байсан тул ганхалтыг нь тааруулж дээвэрт ойртох үед нь ухасхийж гарах шаардлагатай болжээ. Тэгэхэд дотор балартан гутарч байсан тэр сэрэл одоо түүнийг эзэмдэн авлаа. Найман давхрын оройгоос тэртээ доор худгийн ёроолд буй мэт хүүхдүүдийг харахад тэд нар гэдийхээрээ гэдийгээд өөрийг нь харан юу болохыг хүлээж байсан. Мань хүнийг айдас эзэмдэн, шатнаас яг хэрэгтэй цагт нь хөлөө салгаж чадахгүй, дээвэрт хүрч харайлгүй хашааны цардмал талбай руу нисэж ойчих гээд байх шиг санагдсан билээ.

Одоо мөрдөн байцаагчийн өмнө сууж байхад яг тэр амь алдаж мэдэх аймаар тоглоомын сэрэл түүнийг эзэмдэн, зүрх нь яг тэр үеийнх шиг аврал байхгүй гутран шимшрэв. Хийсэн хэрэг нь ёстой юм гэж тоохын аргагүй шал дэмий өчүүхэн зүйл, гэтэл улс төрийн гэмт хэргийн хаяг зүүж, баривчилж, шоронд хийж, мөрдөн байцаагаад ирэхээр энэ хэрэг үнэхээр аймшигтай болж байна. Өөрийнх нь өмнө түүний нөхөр, коммунист хүн сууж байгаа атал Саша түүний хувьд бол дайсан нь болжээ. Тэглээ ч гэсэн өөрийгөө хамгаалах л хэрэгтэй, нөгөө ярихаар зэхэж байсан юмаа ч ярих л хэрэгтэй. Тэгээд Саша Азизянтай зөрсөн явдал, ханын сонин, Сольц энэ тэрийн тухай шоронгийн өрөөнд олон дахин давтсан үгээ ярьж өглөө.

—Та чинь төв шалган байцаах комисс таныг сэргээн тогтоосон гэж ярьж байна шүү дээ.

—Тийм, сэргээн тогтоосон.

—Тэгвэл таныг тэр хэргээр баривчилсан биш, өөр ямар нэгэн юмнаас болж дээ...

—Өөр юу ч байхгүй.

—Панкратов, та бодоод үз л дээ. Таныг нягтлан бодох бүртгэлийн багштай маргалаа гэж эсвэл тэр нэг золгүй ханын сониноос болж баривчиллаа гэж үү дээ? Бид энд ямааг тэмээ болгоод сууж байна уу? Та ч онцгой комиссын тухай хачин бодолтой хүн юм аа.

—Надад ямар ял тулгаж байгаа юм бэ?

—Албан ёсны ялыг мэдэх гээ юу? Тэгвэл дийлмээр санагдаж байна уу?

—Би юуны учир баригдсанаа л мэдэх гэсэн юм.

—Бид бол энэ тухай таныг өөрөө хэлээсэй гэж хүсэж байна. Танд намын өмнө илэн далангүй үнэнч шударга байх боломж олгож байна шүү дээ.

–Та намайг юунд сэрдэж байгаагаа хэлчих, тэгвэл би хариулья.

–Та хэнтэй хувьсгалын эсэргүү юм ярьсан бэ?

–Би юу? Хэнтэй ч яриагүй! Би тийм ярьсан байх учиргүй.

–Тэгвэл хэн тантай ярьсан бэ?

–Надтай ч бас хэн ч яриагүй.

–Та тэгж зүтгэж байна уу?

–Тэгж байна.

Дьяков хөмсгөө зангидан ширээн дээр байгаа цааснуудаа хажуу тийш нь тавив...

–За тэгвэл яая гэх вэ, тун тоогүй байна. Бид танаас өөр юм хүлээж байсан юм. Та чин сэтгэлээсээ үнэнээ хэлье гэж бодохгүй байх шив. Ингэлээ гээд таны байдал дээрдэхгүй дээ.

–Сургууль дээр болсон явдлаас өөр надад хийсэн хэрэг байхгүй.

–Тэгвэл таныг зүв зүгээр байхад чинь баривчлаа юу? Бид гэмгүй хүмүүсийг шоронд хийдэг байх нь уу? Та энд хүртэл хувьсгалын эсэргүү ухуулгаа үргэлжлүүлж байна. Бид чинь харгис цагдаагийн газар биш, Гуравдугаар тасгийнхан[5] биш, зүгээр л залхаан цээрлүүлдэг байгууллага ч биш. Бид бол намын зэвсэгт отряд. Харин Панкратов, та бол хоёр нүүртэн, та ийм л хүн байна!

–Та намайг тэгж нэрлэж болохгүй!

Дьяков гар зангидан ширээ шааж,

–Надад юу болох, юу болохгүйг би танд үзүүлээд өгнө өө! Амралт, сувиллын газар ирсэн юм шиг бодож байна уу? Тань шиг хүнд зориулсан өөр нөхцөл манай энд бий. Хоёр нүүртэн! Та нударганчуудын оготор бууны бай болж үзсэнгүй. Та бүх насаараа ажилчин ангийн нуруун дээр суусан, одоо ч гэсэн улсын нуруун дээр сууж байна. Улс таныг сургаж, оюутны цалин өгч байна, гэтэл та улсаа хуурч мэхэлж байдаг! гэв.

Тэрээр нэг хэсэг баргар царайлан дуугүй сууснаа ямар ч ашиг, хэрэгцээгүй үүрэг биелүүлж байгаа мэт сэтгэл гонсгорхон,

–За яая гэхэв, таны саяын бурсныг чинь л биччихье гэж өгүүлэв.

Тэгээд Сашагаас ханын сониныг хэнтэй, хэзээ гаргасан, тоо бүртгэлийн багштай зөрсөн явдал хэзээ юуны учраас болсон, хэзээ, хаана хасагдаж хөөгдөж байсан, тэгэхэд ямар ял тулгаж байсан бэ? гэхчлэнгийн товчхон асуулт хаа нэг асуун юмаа бичиж гарлаа.

Бичиж дуусаад түүнийгээ Сашад сарвайж,

–Уншаад гарын үсэг зурчих гэв.

Тэгээд арагшаа наллаа. Тэрээр өөрөөс нь нүд салгахгүй байгааг Саша ойлгов. Дьяков энэхэн чөлөөг ашиглан түүнийг сайтар ажиглаж, царай нь яаж хувирахыг анхааралтай ширтэн байв. Бүх юм зүйтэй бичигдсэн хэрнээ нэг л өрөөсгөл болжээ. Баярт зориулан ханын сонины дугаар гаргасан, түүндээ гавшгайчдын хөдөлгөөнийг муулсан шоглол шүлэг оруулсан, үүнд тийм тийм хүмүүс оролцсон, үүр болон районы хорооны шийдвэрээр хөөгдсөн... Мэдээж энэ бүхэн бол мөрдөн байцаалт явуулсныг нотлох гэж хэлбэрийн төдий бичиж байгаа зүйл, харин баривчилсан шалтгаан бол харваас өөр юм байгаа.

Гэлээ ч гэсэн мань хүн,

–Намайг Төв шалган байцаах комиссын шийдвэрээр дээд сургуульд буцааж оруулсныг энд бичээгүй байна гэж хэлэв.

Дьяков хөмсөг зангидан хуудсыг авав.

–Сургуулийн тушаалд буцааж авсан тухай юу гэж бичсэн бэ?

–Яг зөв гэхээргүй бичсэн...

Дьяков түүний үгийг тасдан,

–Би яаж бичих хэрэгтэй байсныг асуугаагүй, яаж бичсэнийг асууж байна гэв.

–“Оюутан Панкратов алдаагаа хүлээснийг харгалзан...”

Дьяков үзгээ авч түрүүчийн бичсэн зүйлийн доор “Хожим намайг алдаагаа хүлээсэн хүний хувьд сургуульд буцааж авсан” гэж нэмж бичив.

Тэрээр цаасаа Саша руу дахин сарвайв.

Саша гарын үсгээ зурлаа. Дьяков хуудсыг авч хажуу тийш тавив.

–Панкратов, дахин сайн бодохыг танд зөвлөе. Бид таныг нийтийн үйл хэргээс алдахыг хүсэхгүй байна. Чухам энэ учраас л бид тантай ингэж зууралдаж байгаа юм. Бид таныг өршөөж байна, та ойлгох хэрэгтэй. Бас үнэлэх хэрэгтэй. Толгойдох юмаа ух л даа, сайн ух.

Тэрээр ширээний араас босож хаалга онгойлгон харгалзагч руу дохиж,

–Аваад яв! хэмээв.

Саша эргэж ирж өрөөндөө орвоос ард нь хаалганы түгжээ хяхтналаа. Цонхны булингартай шилний цаанаас өвлийн одод түрүүчийн янзаар гялалзан байна. Одоо чинь шөнө үү, эсвэл өглөө юу?

Тэгвэл хана тоших сонсдов. Хөрш нь түүнийг хааш нь аваачсаныг асууж байгаа бололтой.

Саша хуучин янзаараа гурвантаа тогшиж хариулаад хувцсаа тайлалгүй орон дээрээ хэвтээд өгөв.

Дьяков өөрөөс нь юу хүсээд байна вэ? Ямар үнэнийг хэлэх ёстой юм бэ? “Хэнтэй хувьсгалын эсэргүү юм ярьсан бэ?” Юун яриа вэ? тэрээр дэмий л элдвийг таамаглан бодохоос цаашгүй. Сургууль дээр болсон явдлаас болж баривчлагдсан гэдэгтээ баг итгэж байсан. Гэтэл тийм биш гэдгийг сонсоод мэл гайхан цэл хөхөрч, хамаг юм толгойд нь хутгалдаж гүйцлээ. Өөрийгөө ойлгуулж, итгүүлнэ гэж горьдож байсан. Гэтэл бүр шал эсрэг юм боллоо. Сургуулийн явдал баривчлах шалтаг биш юм бол өөр шалтаг байх нь. Прокурор тэр шалтгийг найдвартай зүйл гэж үзсэн болж байна. Түүнийг хувьсгалын эсэргүү хэрэгт яллах санаа хэний толгойд орж ирдэг байна вэ? Түүнд намтай зөрж байгаа юм байхгүй. Зусар бялдууч этгээдүүд Сталинд зулгуйдаж байгаа нь үнэн, гэхдээ тэрээр энэ тухай хэнд ч хэзээ ч юм яриагүй, энэ бол Сталины гол юм биш. Мань хүн ганцхан Маркт л хэлсэн, гэтэл Марк энэ яриаг хүнд заяа нь дамжуулахгүй. Аягүй бол тэр бас баригдчихсан юм болов уу? нөгөө бүрэн эрхт нэгжлэг хийж байхдаа түүний зургийг барьж авч эргүүлж тойруулж тал талаас нь харж байсан. Дьяков түүнээс Маркийн буруутгах мэдүүлэг олж авах гээд байгаа юм болов уу? хулчийж бууж өгнө гэж горьдоо юм уу?

Будягин юм болов уу? Магадгүй. Тэр чинь Эйсмонттой нөхөрлөдөг билүү, эсвэл Смирновтой билүү? Смирновынхон бас Тавдугаар байшинд аж төрдөг. Смирновын охин гэж цайвар хонгор үстэй нэг пагдгар охин тэдний сургуульд сурч байсан. Иван Григорьевичийг хавар яг Смирнов, Эйсмонт нарын хэрэг явдлын дараахан гадаадаас эргүүлэн дуудсан. Тэгээд л Будягин Глинскаяд утасдсан, Саша Будягиныхаар орж гардаг энэ тэрийг мэдчихээд одоо Иван Григорьевичийг буруутгах мэдүүлэг олж авах гэж байгаа хэрэг. Энүүн шиг дэмий юм байхгүй! Мань хүн л өөрөө элдвийг ургуулан бодож зохиож байна. Зээ болж төрсний төлөө хүнийг баривчилдаггүй, бас хэн нэг хүнтэй нэг ангид байсны төлөө бас баривчлахгүй. Ямар нэг юмнаас л болж түүнийг энд байлгаж байгаа... Мөрдөн байцаагч зүгээр худлаа жүжиглэнэ гэж байхгүй шүү дээ.

Саша сүүлийн хэдэн сарынхаа явдлыг өдөр хоногоор нь дэс дараалан бодож үзлээ. Уурандаа болоод ямар нэг юм донгосчихоо юм болов уу? Тэрээр сургууль дээр болсон явдлаа хүртэл хэнд ч яриагүй билээ. Нина, Лена, Вадим, Макс, Юра гээд зөвхөн нөхдүүд нь мэдэж байсан. Өө, Юра Шарок! Шинэ жил тэмдэглэхэд тэдний хооронд үүссэн хэрүүл... Гэхдээ Юра ийм юм хийж зүрхлэхгүй. Тэдний группийн нөхдөөс юу билээ? Ковалёв? гэтэл сургуулийн явдал хамаагүй гээд байгаа шүү дээ. Тэгэхлээр юу байх вэ?

Өдөр нь ахлах дэслэгч цолтой шоронгийн нэг түшмэл өрөөнд нь орж ирэв.

Саша гэртээ сурчихсан зангаараа өөрийн эрхгүй босов. Ийм зуршилтай болсондоо хожим өөрийгөө зүхээд зүхээд бараагүй.

–Овог?

–Панкратов.

–Хүсэлт.

–Надад эргэлт ирэхгүй байна.

–Мөрдөн байцаагчдаа хэлээрэй.

–Бас ном сонин?

–Цөмийг нь байцаагч чинь мэднэ.

Тэгээд гараад явчихав. Хянагч өрөөг хаалаа.

Шоронд сууж байж л шоронгийн туршлагатай болно. Анх удаагаа орж ганцаараа хоригдсон хоригдол бол түрүү түрүүчийн үеийн хоригдлуудын боловсруулж, шоронгийн амьдралын ёс хэм болсон бичигдээгүй хэсэг дүрмийг өөрийн ухаанаар сурч мэддэг бүлгээ. Шоронгийн түшмэл орж ирсэн нь Сашагийн хэргийн мөрдлөг эхэлж, тэрээр өөр зиндааны хоригдол болсныг харуулжээ. Сашад ямар санал хүсэлт байх нь түшмэлд пад байсангүй. Тэрээр мөрдөн байцаагчаас Сашагийн цаашдын хувь заяа төдийгүй, энд өөрийг нь ямаршуухан байдалтай байлгах хүртэл бас хамаарна гэдгийг түүнд ойлгуулжээ.

Энэ өдрөөс эхлэн Сашагийн амьдрал гаднаас нь харахад сүүлчийн хэдэн долоо хоногт байсан янзаараа байгаа юм шиг хэрнээ үнэн чанартаа бол тэс өөр болжээ.

Үүнээс өмнө хэзээ байцаах бол гэж тэсэж ядан хүлээдэг байсан бол одоо битүүдээ айж хүлээх болов. Мөрдөн байцаагч гэнэтхэн юу ч тулгаж мэдэх тул Саша тэр болгоныг урьдаас тааж биеэ бэлтгэж чадахгүй учир нэг юм тулгахад нь аягүй бол өөрийгөө зөвтгөх аргаа ололгүй түүнээс болоод мөрдөн байцаагч тэр хоёрын хооронд үл итгэх, хий хардахын зовлон улам нэмэгдэнэ гэхээс өөрийн эрхгүй айна.

Юра Шарокийн эцэг эх Панкратовынханд хэзээний дургүй. Эцгийг нь инженер гэж эхийг нь “дэндүү боловсролтой” хэмээн дургүйцэх агаад нагац нь том дарга нарын нэг болохоор мэдээжээр түүнд бүр дургүй. Сашагийн ээж хашаан дотроо “сэхээтэн” хүмүүстэй ярьж суудаг бол Шарокийн эх лифтчин, хашаачин авгай нартай л үерхэнэ. Сашагийн баривчлагдсаныг тэднийхэн сонсоод “нөхдүүд” хоорондоо мэрэлцэж байна, цөм л бие биенийхээ хоолойг тас мэрэлцэх болтугай хэмээжээ.

Гэхдээ Юра Шарок Сашагийн баригдсаныг яаж мэдээгүй юм шиг байх билээ. Сайн ч бай, муу ч бай эрхиш нэг бүлгийнх юм чинь.

Гэтэл мань хүн энэ бүлэгтэй юугаараа холбоотой билээ? Жинхэнэ нөхөрлөл байхгүй, уймраа Нина, маанаг Максим, чалчаа Вадим энэ тэр түүнийг зүгээр л тэвчисхийгээд явж байгаа. Тэд нар одоо Сашагаа харамсан гасална, мань хүн тэдэнд нэмэр болж чадахгүй.

Лена... Цэвэрхэн, аятайхан, сайн хүүхэн, гэхдээ нэг л хүнийрхүү санагдана. Хүний авгай болж чадахгүй. Тэр хүүхэн юу чадах вэ? Кофе чанахыг уу? Ая тал засахыг хичээвч дүй муутай болохоор дургүй хүргэхээс цаашгүй. Түүнээс гадна насаар өөртэй нь чацуу. Эцэг нь жартай гэхэд ямар байна даа! Лена дөч хүрмэгцээ л нөгөө Ашхен Степановна ээж шигээ бүдүүн амьтан болчихно. Сталин Будягины хувьд сэтгэл дундуур байгаа. Үүнийг Лена хэлсэн. Гэтэл “Сталин сэтгэл дундуур” гэдэг юу байдаг, юугаар төгсдөгийг мань хүн сайн мэднэ. Зөвлөлүүдийн байшин, сайхан байр энэ бүхэн цөм нүд хуурах зүйл. Будягин зөвлөлтийн хууль цаазын тухай өөрт нь номлоод байсан, гэтэл тэр өөрөө хууль цаазын тухай юу мэдэхсэн билээ? Тэрээр намын гэнэн цагаан сэтгэлдээ хөтлөгдсөөр нэгэнт хоцрогдсон хүн. Энэ байтугай юмыг нугалж чадах хүч үүсээд байна. хэрвээ Будягин балрах юм бол мань эр эцгийнхээ өмнө ямар хүн болох вэ? Ардын комиссарын охин гэдэг энэ дээ!

Больё, чи минь! Хөөрхөн охид Москвагаар дүүрэн байна. Вика Марасевич гэхэд л дохих төдийд наалдаад ирнэ. Бас Варька Иванова! Цэврүү шиг бүсгүй.

Тэрээр Ленад долоо хоног утасдсангүй. Бүсгүй өөрөө л утасдана биз. Гайгүй тэгэхээр нь дахиад хэзээ ч утасдахгүй болохоор юм хэлж өгнө. Гэвч харилцуураас “Юрочка, чи хаагуур алга болоод байна аа?” гэх бүсгүйн дууг сонсмогц тэрээр самгардан түгдэрч ажил ихтэй, дипломоо бэлтгэж байна, хуваариа хөөцөлдөж байна, гэртээ арван хоёр болох гэж байхад ирдэг, сургууль дээр цорын ганц автомат утастай, ядахдаа тэр нь эвдэрхий гэхчлэн гүвтнэв.

Бүсгүй харилцуурыг алгаараа хашаад,

–Би чамайг санаад байна гэв.

–Сулрахаараа утасдъя. Чадвал ирэх долоо хоногт.

Тэрээр ирэх долоо хоног төдийгүй түүний дараачийн долоо хоногт ч бүсгүй рүү утасдсангүй. Ер нь утасдахгүй. Ямар ч тайлбар яриа хэрэггүй!

Гэтэл Лена өөрөө утасддаг байна.

–Юра, надад чамтай уулзах хэрэг байна.

–Би сулрахтайгаа зэрэг утасдана гэж хэлсэн шүү дээ.

–Чамтай яаралтай уулзах шаардлага байна.

–Тэгвэл яахав. “Художественный” кино театрын дэргэд есөд уулзъя гэж Юра дурамжхан бувгнав.

Тэр хоёр Арбатын талбайг тойрч Никитийн цэцэрлэгт гудамжийг өгсөв. Жавар гэж ч чөмөг царцмаар. Лена оготор үстэй дээлтэй, улаан бээлийтэй байх бөгөөд ноосон алчуураар чихээ таглан боогоод дээрээс нь дугариг үстэй малгай өмсжээ. Ботинкных нь түрий цэх хөлийнх нь бондгор булчинг жимбийтэл барьсан байх нь Юрагийн сэтгэлийг байнга гижигддэг билээ. Хажууд нь энэ сүрчигний танил үнэр. Өнөөдөр эцсийн удаа ч юм билүү?

–Саша! Ёстой аймаар юмаа гэж Лена өгүүлэв. Цаадах нь дал мөрөө хавчив.

–Баривчилсан...

–Чи түүнийг өрөвдөхгүй байна уу?

–Өрөвдөх, өрөвдөхгүйдээ биш. Тэр чинь ад үзэхгүй хүн гэж байхгүй. Тэгээд ч би түүнд итгэдэггүй юм, нээрэн итгэдэггүй шүү.

–Сашад итгэхгүй гэнэ?

–Намайг комсомолд элсэж байхад Саша “Би Шарокт итгэхгүй байна” гэж хэлж байсан. Тэглээ гэж хэн ч хачирхаагүй. Гэтэл намайг итгэдэггүй гэж хэлэхээр хүний дургүй хүрч байх шив.

Бүсгүй Юраг уурлах нь гэж айж мэгдэв.

–Манай нөхдүүд чамд сайн шүү дээ. Би худлаа хэлэхгүй.

–Тэд нар чинь намайг хөөрхийлдөг. Чи ч гэсэн тэр.

Лена яах учраа олохгүй түүн рүү харлаа. Мань хүн хоёр долоо хоног утасдаагүй, одоо хэрэлдэх дөгөө эрээд байна. Үүнээс болоод чухам хэлэх гэсэн юмаа айгаад хэлж чадсангүй.

Никитийн хаалга хүртэл дуу шуугүй явцгаав.

–Буцах уу?

–Пушкины хөшөө хүрье. Ажил явдал чинь ямар байна, ярь л даа.

Цаадах нь ярих юм юу байх вэ, залхаж гүйцлээ гэх шиг дал мөрөө хавчив.

–Хуваарь чинь юу болж байна?

–Юу ч болоогүй.

Цас бүрхсэн Пушкины хөшөө талбай дээр сүрлэг харагдана.

–Сууя. Би ядраад байна.

Тэрээр дурамжхан царайлан сандлын цасыг цэвэрлэж бүсгүйд суух газар гаргав. Өөрөө зогсогнох юм байж. Страстной сүм рүү хараад ингээд зогсож байх юм гэнэ. Бүсгүйн түгшүүртэй санаа алдахыг сонсголоороо биш биеэрээ мэдрэв.

–Юра, би жирэмсэн болчихжээ.

–Чи сайн мэдэж байна уу?

–Мэдэж байна.

–Юм чинь саатсан байлгүй дээ?

–Бүр хоёр долоо хоночихлоо. Түүний бүсгүйтэй уулзаагүй хоёр долоо хоног тэр.

Хоёр долоо хоногийн өмнө бол ямар нэгэн арга бодож олохсон, одоо бол үр хөндүүлэх л болж... Яагаад ийм дээ хүрчихэв ээ? Мань эр тун болгоомжтой байсан шүү дээ. Ийм тохиолдолд хэрэглэх гадаадын элдэв эм тан энүүнд даанч байдаггүй юм байх даа?

–Чи янз бүрээр оролдоогүй юу?

–Чамтай л зөвлөх гэсэн юм.

–Би эмч биш шүү дээ.

Юра ингэж хэлснээ бүсгүй гагцхүү өөрийг нь чадах гэж жирэмсэн болчихсон юм шиг хачин царайлж,

–Би ийм байдлаар танайд хүргэн орохыг хүсэхгүй байна гэж нэмж хэлэв.

Бүсгүй сэргээд ирлээ.

–Энэ ямар хамаа байсан юм бэ?

–Хүлээх хэрэгтэй.

Тэрээр хүүхэнтэй зэрэгцэн сууж гарыг нь атгаад бээлий ханцуй хоёрын зааг дахь бүлээн арьсыг мэдрэв. Ээ дээ, үгэнд л орох болтугай, мугуйдлаад зөрчих вий, чи минь.

–За чи сайн ойлго. Сургууль, хуваарь энэ тэр гээд цөм тодорхойгүй, яах нь мэдэгдэхгүй байна... Түүнээс гадна Саша. Түүнийг бидний эгнээнээс зүгээр баллаад хасчихгүй шүү дээ... Юм төвөгтэй болчихоод байна, улам төвөг оруулахын хэрэг байхгүй. Тэгэхлээр одоо тэгдэг цаг биш. Энэ бол тун эвгүй мэс засал гэдгийг би мэдэж байна, гэхдээ хэдхэн минутын явдал. Чи бид хоёр хүүхэдтэй болохдоо л болно, одоо бол тэвчиж хүлээе. Бас манай эцэг, эх гэж бий... Хуучны улс болохоороо эхлээд гэр бүлийн товчоо, дараа нь хүүхэд байх ёстой гэж хэлнэ. Энэ мэдээж бэртэгчин үзэл, гэхдээ би элдэв хов жив хүсэхгүй байна, энэ бол доромжлол болно, чи ойлгох ёстой.

–Би ойлгож байна хэмээн Лена гунигтай өгүүлэв.

–Явья, тэгэхгүй бол чи хөлдчихнө.

Тэрээр босож бүсгүйд гараа өгснөө хоёр долоо хоног бол юу ч биш гэдгийг ойлгож байгаа хэрнээсээ тэсэж чадалгүй түүний биеийг анхааралтай харлаа. Тэгтэл санаа дагасан юм уу бүсгүй бүдүүрчихсэн мэт санагдаж сандлаасаа хүндхэн өндийлөө. Юугаар дуусаж болох байж вэ? гэхээс мань эрийг айдас эзэмдэн авав. Долоо юм уу найман сарын дараа өөрөө мэдэлгүйгээр эцэг болчихсон байж мэдэх нь. Тэгээд нэг насаараа тийм болно гэсэн үг.

Бүсгүй ичингүйрэн инээмсэглэж,

–Одоогоор анзаарагдах юм байхгүй ээ гэв.

Тэр хоёрын хувьд ийм шөнө үүнээс өмнө байгаагүй ажээ. Бүсгүйд орчлон дээр энэ залуугаас үнэтэй юм гэж үгүй тул чухам түүнийг л бодож үр хөндүүлэхийг зөвшөөрөв. Түүнийг ийнхүү дуулгавартай байгаад Юра уяран, бахархах сэтгэл бялхаж бүсгүйг энхрийлэн таалахын хамт өөртөө улам татаж аргамжиж аваад ерөөсөө үгнээсээ гарахгүй болгохыг хичээлээ. Орчлон дээр бүх юм дахин давтагдсаар ирсэн, хойшид ч түм бум давтагдана, энэ тухайд Лена анхных нь ч биш, эцсийнх нь ч биш, хүүхнүүдийн ердийн л явдал шүү дээ. Мань эрийн эх гэхэд л долоон удаа үр хөндүүлсэн, тэдний тосгонд жирэмсэн охидууд хашааны том хаалган дээрээс газар харайж буугаад л байдаг, тэгээд үхсэн үрэгдсэн хүн байдаггүйдэг. Амьдралаа төвөгтэй болгохын хэрэг байхгүй, зун хоёулаа Сочи явна, тэнд одоо дээд зэргийн амралтын газар бий гэж ярьдаг, өөрөө үгүйдээ далай үзнэ, Москвагаас өөр ер юу үзсэн билээ дээ? Лена бол орчлонгоор сэлгүүцчихсэн хүн, гэтэл мань эр?

Юра бүсгүйн сэтгэлийн хамгийн уяхан чавхдасыг хөнджээ. Түүний учирлаж ярьсан зүйл ард түмний энгийн агаад сийрэгхэн сайхан ухаан шиг санагдсан аж. Нээрэн түүнд одоо хүүхэд шуухад бусад элдэв юмаар яршиг төвөг удаж яаж болох вэ дээ, тэглээ гээд татсан биш түлхсэн хэрэг болно. Тэрээр түүнд саад тотгор гавихгүй хэзээ ч өөрийгөө буруутгуулах хэрэг хийхгүй. Жирэмсэн болсон тухайгаа ч зүгээр л хэлсэн хэрэг, өөр хэнд хэлэх вэ дээ? Тийм учраас энэ тухай бүү бодог, бүү санаа зовог.

Энэ явдал тэр хоёрыг дотно болгожээ. Юра хэзээ ч ийм эелдэгхэн үнэнч, ийм хөөрхийлэлтэй байгаагүй. Лена түүний айж балмагдсан байхыг анх удаа үзэж байгаа нь энэ бөгөөд өр зүрхнээсээ өрөвдөж, хайрын сэтгэл улам дэвэрлээ. Өглөө цаадах нь гараа цээжин дээр нь тавиад зүүрмэглэж байхад бүсгүй түүнийг сэрээчих вий хэмээн болгоомжлон хэвтэв. Мань

эр бүсгүйг хуучин удаахыг боддоггүй, шөнөөр нуусхийгээд явуулчихдаг байсан бол өөнөөдөр тавихгүй байлаа. Тэгж тэгж явуулахынхаа цагт үүд хүртэл хүргэж өглөө. Хуучин өлмий дээрээ дохилзон хаалга хяхтнах, цоож торхийх энэ тэрээс учиргүй болгоомжилдог байсан бол өнөөдөр тийм юм огт байхгүй, ичих, зовох, юмгүй чанга чанга ярьж инээмсэглэн хацраа хацарт нь наалаа.

Хашаачин хүртэл сэжиг ажиггүй харсан төдийгүй, өгсөн рублийг нь хуучин шигээ албан хурам шиг биш, үнэхээр “Баярлалаа, та минь” хэмээн талархан авав. Бүсгүйн хөлийн чимээ Арбатаар тайван итгэлтэй тожигнож, тэрээр тийнхүү гудамжаар, өөрийнхөө гудамжаар алхалж яваа нь энэ. Тэгээд гарах гэж шатаар бууж явахдаа Сашагийн байрны хажуугаар өнгөрснийгөө Арбатын талбай хүрсэн хойноо сая л нэг тогтож бодлоо. Энэ тухай яагаад дөнгөж одоо л толгойд орж ирж байна вэ? Хайр сэтгэлдээ автаж байгаад бусад хамаг юмыг мартаж орхио юу? Гэтэл Софья Александровна шөнөжин нүд хамхихгүй “Саша минь одоо яаж байгаа бол?” гэж бодоод ганцаараа хэвтэж байгаа...

Гурван өдөр эмнэлэгт хэвтэхийг нуухын арга байхгүй. Будягиныхан одоо ч охиноороо үнэнийг хэлүүлчихэж магадгүй, ээжээс юм нуух аргагүйн дээр ээж энэ талаар нарийн мэдлэгтэй шүү дээ. Ленка худлаа мэлзэж сураагүй, мэлзэхийн хэрэг ч юу билээ, энэ бол зохисгүй зүйл. Хэнээс олсон тухайд дор нь таамаглачихна. Тэгсэн цагт төрүүл, чиний Шарокийг аяа олно гээд ятгачихна даа.

Толгойд нь юу эргэлдээд байна вэ? Юра түүний ажил руу нь угасдсан, ярихдаа тун эелдэгхэн байсан, харин ажил явдал их, тийм учраас дээрээс нь өөрийнхөөрөө нэмж бүү зовоо гэх шиг дуунд нь ядарсан шинж мэдэгдэж байсан. Арбатын жирийн охид түүнд хэзээ ч ийм яршиг төвөг удаж байгаагүй, өөрснөө л аргалдаг байсан... Цуу? Марганцын уусмал? Хина? Чухам юугаар аргалдаг нь өөрт нь падгүй билээ. Гэтэл энэ гэж нэг ээжийн эрх танхи охин юу ч мэдэхгүй, юу ч чадахгүй, хилийн чанадад байснаас цаашгүй арилж тонилох нь таарсан амьтан! Үүнээс одоо л хагацахгүй бол дараа нь хэзээ ч хагацахгүй хэрэг болно. Үгүйдээ дутуу гаргачихдаг ч болоосой! Хүмүүс чинь мөстсөн явган зам дээр нисэж ойчоод л байх юм байна шүү дээ, ялангуяа түүн шиг ойрын хараа муутай, хөдөлж цөхсөн амьтад бүр ч амархан ойчдог биш үү.

Шарокийнхан халуун бүл дотроо юм аа илэн далангүй ярилцах нь ховор ч гэсэн Юра ямар ч атугай ээжтэйгээ ярилцахаар шийджээ. Ээж нь жирийн хүмүүсийн хэрэглэдэг нууц юм хумыг мэднэ, дор хаяхад тус болж чадах хүнийг мэднэ. Ээжийнхээ хашаан дотор авгай нартай шивгэнэлдэж байхыг мань хүн үзсэн бөгөөд ийм юмны тухай ярилцдагийг нь царайгаар нь гадарлах болжээ.

Ээж нь одоо энэ тухай сонсмогц нүүр нь толборон нүд нь бүлтийгээд ирлээ. Муухай Лена давхар болж гэнэ ээ, толгой нь хаа явсан өмхий банзал вэ? Нөгөө боловсролтой улс чинь энэ дээ, жирийн хүмүүсээс доор! Хар хүн уургалж байгаа нь энэ гэнэ, гичий чинь! Зөнөсөн өлөгчин, ямар арван тавтай хүүхэд биш өөрөө л учраа олох ёстой!

Юра минь ардын комиссарын охинтой сууна, тэгээд Кремльд амьдрах болно гэж өнөөдөрхөн онгирч сайрхаж байсан авгай одоо ийнхүү хор шар нь буцалж байна. Нөгөө бидний дарга нар энэ нөхдүүд чинь Юрагийн эцэг эхийг босгоороо алхуулдаггүй юм. Тэгэхлээр Юраг ч

алхуулахгүй. Хүүхэдтэйгээ нөхрийндөө бай, тэр чинь тусгай өрөөтэй хүн гэж Ленкадаа хэлнэ дээ. Манай энэ ганц өрөөтэй, гэтэл тэд өөрсдөө гурван өрөөтэй шүү дээ. Нөхөр чинь ээжтэй, тэгэхлээр хүүхдийн чинь асрагч болно гэх биз. Үгүй, гайгүй байлгүй, тэгүүлдэг нь би биш, тэдний шээсийг асардаг нь гонж. Бас энэ хүүхэн орос ч биш! Хамрыг нь харваас еврей! Одоо үр зулбуулсныхаа өртгийг биднээс нэхнэ дээ, шулам чинь!

—Болиоч! хэмээн Юра эхийгээ зандраад,— Ямар арга байдаг юм бэ? гэв.

Эх нь уруулаа жимийснээ,

—Хэдэн сартай юм бэ? гэж албархуу асуув. Үнэн хугацааг нь хэлбэл ээж нь туслахаа больчих байх гэж санаад Юра,

—Хэдхэн өдөр болж байна гэж худлаа хэлэв.

—Халуун ус бэлтгэж байгаад хөлөө сайн халааг. Аль болохоор халуун ус шүү, тэсэж ядмаар халуун усанд дүрээд тэвчих хэрэгтэй. Тэднийд чинь аягүй бол хувин ч байхгүй байх даа.

—Ололгүй яахав.

Тэрээр Лена гэртээ ингэхгүй гэдгийг хэлсэнгүй. Энд, эднийд л хийх хэрэгтэй болно.

Арбатад гич байсангүй тул мань эр Усачевка орж тэндээс худалдаж аваад ээж нь түгжээг нь эвдэхээс айгаад онгойлгож үзэхгүй хэмээн цүнхэндээ нуув. Гал зууханд орж шалгаж үзвэл нэг битгий хэл хоёр хувин байна.

Орой нь тэр хоёр Хувьсгалын театрт очиж “Цүнхтэй хүн” гэдэг жүжиг үзэв. Юрад Гранатов аятайхан санагдсан юмсанж. Гранатовын амьдралд тохиолддог үйлтэй лайг бодохоос өөрийнх нь амсаж яваа хорвоо гэлтэй байжээ.

Тэрээр театрын амрах танхимд хурсан олон хүнийг ажиглаж оо энгэсэг, сүрчигний үнэрийг шимтэн амьсгална. Театрт орох болгоноо баяр гэж үздэг учраас ажлын чөлөөхнөөр босоо суугаа хоёрын завсраар театрт орж гардаг Саша Панкратов, Нина хоёрыг, эсвэл жүжгийг мах үе мөчөөр нь эвдэх мэт задлан шинжилдэг Вадим энэ тэрийг мань хүн хэзээ ч ойлгодоггүй билээ. Завсарлагаанаар,

—Чамд дуулгах сайхан сонин байна. Манай факультетэд Коля Сизов гэж нэг залуу байдаг юм... Эцэг нь алдартай эмч, дуулсан уу? гэж Ленагаас асуув.

—Сизов... Үгүй, дуулаагүй юм байна.

—Анагаахын хоёрдугаар дээд сургуулийн профессор. Эмэгтэйчүүдийн эмч.

Юун тухай ярьж буйг ойлгомогц бүсгүй биеэ хураачихав. Нөгөөдөх чинь мөд болохгүй ажил юм чинь. Шарок өрөвдөхийн сөгөөгүй үргэлжлүүлэн,

—Хөлөө гичтэй халуун усанд байлгах гэж нэг аюулгүй арга байна. Чи мэднэ дээ, салхи авч

шуухинаа хүрэхэд тэгдэг шиг гэв.

Бүсгүй жаахан тайвширлаа.

–Тэр чинь нэмэр байх уу?

–Их нэмэртэй гэлцэж байна.

–Гэтэл зөндөө удчихсан шүү дээ...

–Яг болдог цаг нь.

Түүний эрс тэс байгаагаас бүсгүйн айдас хүрэв.

–Эрхбиш эмчид үзүүлсэн нь дээр юм болов уу...

Цаадах нь өөрийнхөөрөө зүтгэлээ.

–Энэ чинь мэс засал биш, ерөөсөө өвдөх юм байхгүй, халуун усыг жаахан тэвчээд л болоо. Бид юугаараа азаа үзэж байгаа юм бэ? Эсвэл чи бүр болихоор шийдчихсэн үү?

–Больё ч гээгүй л дээ, гэхдээ надад төвөгтэй л байна, гэрийнхэн маань харчихна... гэж Лена аяархан өгүүлэв.

–Тэр ч тийм шүү гэж Юра зөвшөөрөв.

Тэгснээ гэнэтхэн толгойд нь нэг санамсаргүй санаа орж ирэх мэт,

–Манайд хийчихье. Эцэг хамрын ханиад хүрэхээрээ тэгж аргалдаг юм. Бодвол гич бий байлгүй гэж хэлэв.

–Халуун байна уу?

–Дажгүй ээ. Харин ч аятайхан байна.

Лена хүрэн уусмал дүүргэсэн хувинд хөлөө дүрээд орон дээр сууж байлаа. Гич нүд хорсгох тул нүүрээ буруулна.

Цамцных нь шуусан хормойны цаанаас тас хавчсан булцгар хоёр цагаан өвдөг нь ил гарч, бадриун хөл нь хувинд арайхийн багтжээ. Тэрээр бөхийсхийн хоёр гараараа элгээ тэврэн суух агаад дотуур цамцных нь хоёр мөрөвч унаж булхгар мөр нь ил гараад, цэнхэр торон хажлаганых нь цаанаас цээж нь харагдана. Хоёр хөлөө яльгүй хавиран ярвайж инээмсэглэхчээн аядан,

–Харин ч аятайхан байна гэв.

Юра түүний хөл рүү буцламтгай ус гоожуулчихгүйн тулд данхныхаа цоргыг хувингийн хана руу хүргэж байгаад уснаас нэмлээ.

Цаадах нь дал мөрөө хавчгануулан хөлөө улам халирч,

–Лут халуун байна... гэв.

–Тэвчзэнэ, одоохон хөрчихнө...

Тэрээр нэг гараараа данхныхаа сэнжнээс барьж, нөгөө гараараа хувинтай усны халууныг үзэв. Усны халуун болоогүй байх шиг санагдсанд дахиад уснаасаа нэмлээ.

–Ой-ой!

Бүсгүй эвхрэн гийнаж, нүдээ аниад аахилж гарав.

–Тэсээрэй, тэснэ шүү, одоохон зүгээр болно. Леночка минь, одоохон.

Лена арагшаа гэдэсхийж толгойгоороо хана шүргэж, цамцаа базалж тавилан байна.

–Одоо, одоохон зүгээр болно, тэвчинэ шүү...

Хүүхний дух, дээд уруул дээгүүр хөлс бурзайгаад ирлээ.

Юра ус руу хуруугаа дүрж үзээд дахин сэлбэв. Цаадах нь гийнан атиралдсанаа хувингаас хөлөө татсанд мань хүн түүний час улайсан булчинг үзлээ. Өрөөгөөр нэг гичний үнэр таржээ.

–Юрочка, би чадашгүй нь хэмээн бүсгүй гийнаж – жаахан гаргаад орхиё, дөнгөж хоромхон зуур... гэв.

–Одоо ингээд дуусна, дахиад жаахан тэс...

–Миний хөл чилчихжээ, мэдээ алга. Хүний юм шиг болчихож...

Тэрээр шүдээ зууж, нүдээ аниад орон дээр эвхрэн байна.

–Бүгчимхэн оргиод байна...

Юра түүний тарайсан бие рүү бөхийж цамцных нь мөрөвчийг мулталж, хөхнийх нь даруулгыг тайлаад өвдгийг нь илэв.

–За гайгүй, тайван байна шүү.

Тэгээд уснаасаа дахин болгоомжтой нэмэхэд хүүхэн аяархан гийнаж, хөлөө хөдөлгөх төдий болох нь атиралдсан цэнхэр цамцаар бүтээмэр болсон амьгүй том цагаан бие байх мэт.

Юра гал тогоо руу очиж зуухан дээрээс хоёр дахь данхаа авав. Данхны сэнж урван тэрслэх мэт хангинаж, тоогүй олон гагнасан хувингийн бариул бас харжигналаа. Новш хадгалж байдаг дүүрчихсэн толгойнууд шүү! Нэг хүн ороод ирэх шиг болсонд айж балмагдан эргэж харвал гал тогооны үүдэнд ээж нь зогсож байв. Тэр хоёр бие биеэ үг дуугүй харна.

–Хөлийг нь битгий шалзалчихаарай.

Тэрээр юу ч дуугаралгүй өрөөндөө эргэн ирж, хаалгаа сайн хаахад ард унтраалга чадхийн дуугарсан нь ээж нь гал тогооны гэрлийг унтраасан хэрэг аж.

Ленагийн толгой нь дэрэн дээр гилжийж, уснаас цухуйсан хөлийнх нь булчин дээр час улаан зурвас гэрэлтэн байна.

–Леночка, чи унтаж байна уу?

Бүсгүйн сормуус чичисхийв. Тэрээр бараг дуулахгүй шахам аяархан амьсгалж дух, хөмсөг, дээд уруул, эрүү дээр нь том том дусал хөлс гялалзана. Юра тэр хөлсийг алчуурын сэжүүрээр аятайхан арчив.

–Леночка!

–Дотор муухайрч байна хэмээн бүсгүй нүдээ нээлгүй шивэгнэв.

Юра хүүхний толгойг яльгүй өндийлгөөд аманд нь сэнжтэй аягатай ус хүргэв. Бие нь дагжиж байгаа бололтой шүд нь аяганы амсарт тожигнон байж арайхийж нэг балгаснаа усыг дуустал нь хомхойрон залгилаад тамир алдан дэр бараадлаа. Юра түүнийг хөнжлөөр хучаад, уснаасаа дахин нэмэхдээ тун болгоомжтой байсан хэрнээсээ хөл рүү нь цацчихлаа.

–Ай-яа-яа... хэмээн хүүхэн гийнаж, дахин эвхрээд хөнжлийг авч хаяв.

–За за гүйцлээ! Энэ сүүлчийнх...

Бүсгүй даарсан мэт хоёр мөр нь чичигнэн, гар нь салгалан юу юугүй чичрээд ирлээ. Мань хүн дахиад хөнжлөөр хучив.

–За гүйцээ, ингээд гүйцээ.

Бүсгүй арга барагдсан байдлаар аяархан уйллаа.

Юра цагаа харвал нэгээс арван таван минут өнгөрч байв. Дөчин минут өнгөрчээ. За яахав, дахиад таван минут!

Бүсгүй уйлахаа болиод дэр лүү толгойгоо шаан үхсэн мэт хэвтэнэ. Шарок түүн рүү тонгойн духыг нь дарж үзвэл дух нь хүйтэн байв. Чагнаж үзвээс амьсгалж байна. Хөлийг нь хувингаас аятайхан гаргавал яг чаначихсан мэт санагдав. Зүгээр болно... Гичний хурц нясуун үнэр өрөөгөөр дахин тархлаа. Тэрээр бүсгүйн хөлийг орон дээр гаргаж хөнжлөөр хучаад хувинтай усаа гал тогоо руу аваачиж асган угаагуурын гичийг арилгаж бүх сав суулгаа зайлж байр байранд ив тавиад өрөөндөө эргэж ирлээ.

Лена унтаж байв. Мань хүн цонх руу очиж хөшгөө ярлаа. Хажуугийн байшингийн шатны талбайнууд бүдэгхэн гэрэлтэж төмөр утсан тортой чийдэнгүүд хөөрхийлмөөр анивалзан байна. Шал дэмий ажил л болоогүй байх болтугай. Танхи амьтан. Өөр хүүхэн бол ёо ч гэхгүй байсан даа. Ингэлээ гэж үхэж байсан түүхгүй. Ямар нэг юм л түрхчихнэ биз.

Тэрээр хувцсаа тайлж гэрлээ унтраагаад Ленагийн хажуугаар хэвтэж хөлийг нь аятайхан зайчлаад хөнжлийн захнаас татаж нөмрөв. Хөдөлгөөнгүй тарайн хэвтэж буй хүүхний биеэс халуун төөнөж, гичний хурц бөгөөд дотор гижигдсэн үнэр ханхаллаа... Тэгээд хөдөлгөөнгүй, хариу байхгүй хүүхнийг тэврэн авахуйд ха-риуцгүйгээсээ болоод сэтгэл улам ч гижигдэх аж. Үүнд урьд өмнө амсаж үзээгүй, араатных гэлтэй ямар нэгэн хурц сэрэл байх амуй. Мань эр бүсгүйн дотор хэдийн бий болж, өөрийнх нь амьдралыг баллахаа алдсан өчүүхэн тэр үр хөврөлийг устгаж, эхээс нь тасдан хаяж чадахуйц хүчтэй цочиргоо үүсгэхийг хичээсэн билээ. Тэгээд бүсгүй ёолон гийнамагц түүний дотор үүсэн бий болсон тэр нэгэн өөр амьдрал сая нэг устлаа гэж боджээ.

Бүсгүй өглөө нь оймсоо өмсөж чаддаггүй ээ.

–Өвдөөд байна.

Дараа нь ботинк нь багтахгүй болчихсон учир бас өмсөж чадсангүй. Юра түрийг нь ярж огтолсон том эсгий гутал авчирч өгөв.

Лена эсгий гутлыг өмсөж өрөөн дундуур дүй муутайхан болгоомжтой явж үзээд,

–Одоо уужуухан байна гэв. Тэрээр тэр дорхноо намхан пагдгар болчих шиг санагдаж сэлхэрсэн цонхигор царайтай, зовсон нүднийх нь доод зовхи хөвхөртсөн энгийн нэгэн эмэгтэй болж хувирлаа.

Тэгснээ гэнэтхэн орон дээр суун тусав.

–Толгой эргээд явчихлаа.

Юра түүнийг дөхүүлж өгөхөөр шийдэв. Аягүй бол гудамжинд ойчих ч юм билүү... Уул нь аяга халуун цай өгчихвөл зүгээрсэн, гэтэл ээж нь хэдийн гал зуухандаа юм оролдож байгаа тул түүнийг байхад Юра тийшээ ормооргүй байв.

Тэр хоёр хашаан дотор хүнтэй тааралдсангүй. Арбат хүрээд талхны мухлагийн дэргэд танил хүмүүс дугаарлан зогсож байсан тул мань эр гудамжны нөгөө тал руу гарлаа. Лена түүний гараас түшин аажуухан явж байв. Сугадаж явах цагаа мөн олов оо. Гэвч энэ бол энэ хоёрын хамт яваа сүүлчийн зам, үүгээр дуусгах хэрэгтэй. Битгий уначихаасай, яаж ийгээд л гэрээ хүрчихээсэй. Өнөөдөр үүний ажилладаггүй өдөр юм чинь хэвтээд амарчихна биз. Бүсгүй өөрийнхөө байрны хашаан дундуур ганцаараа явж, орцондоо ормогц эргэж хараад түүн рүү инээмсэглэв.

Мань хүн өдөр нь утасдаж яасан тухай мэдэх гэсэн боловч яарна гэдэг бол санаа зовж байгаагаа илчлэхийн хамт үйлдсэн хэргийнхээ аюултайг харуулсан хэрэг болно гэж санаад утасдсангүй. Маргааш ажил рүү нь утасдчихна. Ажилдаа очсон байвал эрүүл гэсэн үг, юм нь болсон бол тэрийгээ хэлнэ. Бүсгүй ажил дэрээ байж байв. Тэгээд харилцуурыг гараараа хашиж байгаад аяархан боловч тов тодхон,

–Жин тан болсон гэж өгүүлэв.

Энэ мэдээ түүнийг баярлуулна гэсэндээ бүсгүй өөрөөр баяр хөөр болж байгаа нь дуунаас нь илт байв.

–За баяр хүргэе, сайн байна, чамайгаа үнсье, би чам руу дахиад утасдана аа гэж хэлээд Юра харилцуурыг өлгөлөө.

Тэрээр дахиж утасдахгүй, ингээд болоо. Хоёр яс хагацах нь тэр!

Юраг орой сургуулиаса ирэхэд ээж нь,

–Нинка Иванова утасдсан гэж хэлэв.

–Юун хэрэг болчихоо юм бол?

–Чамайг утасдаарай гэсэн.

Сашкагийн тухай элдвээр санааширч баахан чаргуулдах нь. Тэд нар надад падгүй, нохой гахай руугаа тонилцгоовол таарна!

Нина дахиад утасдлаа.

–Лена яасныг мэдсэн үү?..

Түүний зүрх нь зогсчих шиг болов.

–Юу болоо вэ?

–Цус алдсан

–Хачин юм даа. Бид хоёр үнэндээ ойрд уулзаагүй, гэхдээ өнөөдөрхөн утсаар ярьсан. Ажил дээрээ л байсан шүү дээ.

–Ажлаас нь аваад явсан байна.

–Аль эмнэлэгт байгаа вэ?

Нина хотын зах хавьд байдаг нэг эмнэлгийн дугаар, хаягийг хэлж өгөв.

Юра хэсэг зуур тээнэгэлзсэнээ,

–Цаадах чинь юунаас тэгээ юм бол? гэж эрсхэн асуув.

–Бүү мэд.

–Эмнэлэгт байгаа гэж хэн чамд хэлээ вэ?

–Ашхен Степановна. Лена хүнд байгаа гэнэ.

–Утасдсан чинь сайн байна, баярлалаа. Би эмнэлэг рүү нь очно оо.

Тэрээр өрөөндөө буцаж орж хаалгаа хаагаад ширээ рүү суув. За ингээд орооцолдчихлоо доо! Мань хүн муу ч гэсэн хуульч юм чинь хуулийг сайн мэднэ. Нууцаар үр хөндөгч... Хохирогчийн амь насыг бүрэлгэсэн үйлдэл... Тэнэг толгой! Ийм юмыг яах гэж гэртээ хийвээ! Хүүхэн гэртээ хийвэл болох л байсан, тусгай өрөөтэй юм чинь, хэнд ч харагдахгүй байхсан. Ээ тэнэг! Тэнэг! Ээ хар тэнэг!

Бүсгүй хэрэв үхэхгүй бол түүнийг илчлэхгүй. Хэрэв үхвэл мань хүн юу ч байсан мэдэхгүй л гээд зүтгэчихнэ. Баталгаа байхгүй. Түүний жирэмсэн гэдгийг мэдэж байсан нь үнэн, бас гаргах дургүй ямар нэг арга чарга хэрэглэж байсныг нь мэднэ, гадаадын ямар нэг эм тан хэрэглэж байгаа байх л гэж бодсон, гэхдээ чухам яаж байсныг нь одоо хүртэл мэдэхгүй байна гээд хэлчихнэ. Хэвтэхийнх нь урьд өдөр бие муу юм уу гэмээр царайтай байсан, мань хүн түүнийг гэрт нь хүргэж өгсөн, маргааш нь ажил руу нь утасдсан, тэр хоёр шиг дотно улсад энэ бүхэн бол зүй ёсны хэрэг, гэхдээ хэрэгт оролцсоныг нотлох зүйл биш.

Бас тэгээд гичтэй халуун усанд хөл дүрэхийг үр хөндөхтэй адилтгаж болох уу? Хуульчид чухам яагаад энэ үгийг сонгож авсан юм бол? Үр хөндөх! Энэ нэр томъёо утгыг нь дэлгэрүүлж ойлгох эрх олгодог болов уу? “Жирэмслэлтийг зохиомлоор таслах” гэдэг нэр томъёог бол ёстой юу ч гэж ойлгож болно. Гэтэл хуульч үр хөндөх хэмээн түүний анагаах ухааных нь утгаар, өөрөөр хэлбэл мэс засал хийхийг зааж тодорхой хэлсэн байна.

Хэргийн учрыг, нарийн ширийн юмыг сайн бодох хэрэгтэй. Хаана, хэзээ, өдөр, цаг, минут, болсон газар, үнэмшилтэй нарийн ширийн юмнууд. Ленка үхэх юм бол Будягин мань эрээс

салахаа үзэхгүй. Эсвэл хэрүүл шуугиан дэгдээе гэхгүй юм болов уу? өөрөө томоохон зүтгэлтэн байтал охин нь үр хөврөлөө хамгийн болхи бүдүүлэг аргаар зулбуулахыг оролдож байж таарах уу? Ер нь цаад уг ёзоорыг нь үзэх юм бол явж явж энэ Будягиныхан чинь өөрсдөө л хэргийн эзэд. Тэд нар л энэ хоёрын гэрлэхийг эсэргүүцсэн, чухам үүнээс болж л Лена хүүхдээ төрүүлэхгүй гэсэн. Тэгэхлээр гол хариуцлага тэдэн дээр бууна. Тэд нар түүнийг ийм хэрэгт өөрийн эрхгүй түлхэж оруулсан байна. Магадгүй, зөвхөн өөрийн эрхгүй ч биш юм билүү? Нийтэд мэдэгдэхийг хүсээгүй байна. Уг үндсийг нь тунгааж үзвэл энэ явдал иймэрхүү байдалтай, ийм янзтай толгойд бууж байна. Тэд нар охиноо юунд зориулан бэлтгээ вэ? Юу сургаа вэ? Англи хэлнээс орчуулахыг уу? Энэ бол амьдрахад дэндүү багадна. Тэрээр энэ айлыг байнга үзэн яддаг байсан, тэд нар байдлыг одоо бас л гартаа авчихаад байна, мань хүн тэдний эрхэнд орчихоод энд алгынхан чинээ өрөөндөө байж ядаж байхад, тэд нөгөө халдашгүй цайз мэт Зөвлөлүүдийн тавдугаар байшинд эмч нарыг дайчлаад Ленагаа аварцгааж байгаа. Тэгээд аварчих байх л даа, бодвол. Харин дараа нь мань хүнтэй тооцоо хийнэ.

Ээж нь бүх юмыг гадарлаж байвч яриа үүсгэвэл өөрийг нь буруутгаад эхлэх байх гэж айгаад юм ярья гэхгүй дүнсгэр царайлан дуугүй байв. Гэвч түүний буруу гэж юу билээ? Тус больё л гэж бодсон, цөм л иймэрхүү янзаар аргалдаг шүү дээ, юу нь ч танхи хатагтай вэ дээ! Манай энэ ч гэсэн дүүрчихсэн амьтан, хэрээ мэдэхгүй иймдээ хүрчихээд, хүүхний туурайг шалзлаад байгаа юм.

Юра эмнэлэг рүү очсон боловч дотогшоо орсонгүй. Түүнийг хичнээн цөөн хүн харна төдийчинээ сайн. Будягиныхантай таарахаас эмээж, бас шинэ гэрч бий болох вий хэмээн айгаад эмнэлгийн барааг харчихаад буцжээ.

Тэрээр Арбат руу буцаж ирээд гэрээсээ биш автомат утаснаас эмнэлэг рүү утасдаж, өвчтөн Елена Ивановна Будягинагийн биеийн байдлын тухай лавлав. “Биеийн байдал хүнд байна, халуун нь гучин ес найм байгаа”. Өдөр болгон утасдсаар дөнгөж долоо хоногийн эцэс рүү “Биеийн байдал дунд зэрэг, халуун нь гучин найм хоёр байгаа” гэсэн үг дуулав. Дахин гурав хоносны дараа “Биеийн байдал гайгүй, халуун нь хэвийн байгаа” гэсэн хариу сонсов. Хоёр дахь долоо хоногийнх нь сүүлчээр Ашхен Степановна Ленаг гэртээ гаргаж авчирчээ.

Яг энэ орой ээж нь Юрагаас,

–Нөгөө хонгор чинь яаж байгаа вэ? гэж асуув. Тэрээр хямсганан,

–Эрүүл саруул эсэн мэнд байгаа гэжээ.

Эмнэлэгт байхад нь нэг ч удаа очоогүй, зурвас ч бичээгүй, өөрийгөө зөвтгөх ямар ч юм байхгүй болохоор Юра утасдвал цаадах нь хэрхэн хүлээж авахыг мэдэхгүй учир хүүхэнд утасдсангүй. Падгүй хэрэг! Очоогүй нь зүйтэй! Гагцхүү нөгөө явдлын тухай хэн нэгэн хүнд хэлсэн эсэхийг л мэдэж авах хэрэгтэй байна. Гэвч харилцууртаа хүрч зүрхлэхгүй байлаа. Цаадах нь ч бас утасддаггүй. Харин Нина утасдлаа.

–Юра, манайхан өнөөдөр Лена руу очих гэж байгаа, цуг явах уу?

–Би өнөөдөр ажилтай.

–Хожигдоод л очихгүй юу?

–Би бүр оройтож суларна.

Нина өөрөө утасдав уу, эсвэл Ленагийн гуйлгаар утасдав уу? Үүнийг тодруулах хэрэгтэй.

Тэгээд Ленад утасдлаа. Түүний намуухан эелдэг дуу сонорт хүрч,

–Чамайг бүр хүлээж ядлаа! Чиний төлөө санаа зовсон гэдэг жигтэйхэн гэх нь сонсдов.

–Харин би л чиний төлөө зовж байлаа шүү дээ.

–Энэ талаар чамайг яаж байгаа бол? гэж туж бодож байлаа. Яагаад эргэж ирсэнгүй вэ?

–Өдөр болгон утасдаж асууж байсан.

–Өө тийм үү? гэж бүсгүй баярлан асуугаад,

–Өнөөдөр манайхан над дээр ирэх гэж байгаа, чи хүрээд ирэхгүй юм уу? гэв.

–Тийм олон хүнтэй цуг очмооргүй байна.

–Тэр ч тийм шүү, тэгвэл хэзээ ирэх вэ?

–Утасдана аа.

Нина сургуулиасаа таван цагт буцаж ирэв. Хаалганы хавьд шатны гишгүүр дээр Варя, Зоя гэдэг найз охинтойгоо сууж байх ажээ.

–Хаалгаа татчихсан чинь түлхүүрээ мартчихсан юм байж.

Түлхүүрээ мартчихаж гэнэ... Дандаа худлаа ярина. Зояг гэртээ дагуулж ирэхийг хориглосон болохоор шат ямар чиний юм биш, энд байхыг хориглох эрх бий юу? гэсэн шиг ингэж шатан дээр сууцгааж байгаа л даа.

–Бодоход хагас минут, болгоход хоёр минут өглөө шүү гэж Варя Зояд хэллээ.

Энэ ярианых нь байж байгааг.

–Софья Александровнагийнхаар орсон уу?

–Орсон.

–Бүх юмыг нь авч өгсөн үү?

–Бүх юмыг.

–Тасалбарууд?

–Бараа болгочихсон.

–Хичнээн мөнгө үлдсэн бэ?

Варя хариулт мөнгөө өгч,

–Мөсөн гулгуурын газар орох гэж тавин мөнгө би авсан гэв.

–Хичээлээ яах вэ?

–Хийчихнэ ээ.

Хүн болгон өөр өөрийнхөө үүргийг л биелүүлэх ёстой. Нина өөрөө бол ажил дээрээ хайнагийн шар шиг зүтгэхийн хамт гэртээ ирэнгүүт хоолоо идчихээд тал цалин авахын эрхээр оройн сургуульд хичээл хаах гээд гүйчихнэ. Гэтэл Варя гулгуур, театр, кино, найз охид гэхчлэнгийн ажилтай байхыг үзэхүл гэр орны ажил нэг их цаг авдаггүй бололтой.

–Орой агшаасан будаа халааж идээрэй, хайруулын тавганд орхичихно, цөцгийн тос шүүгээнд бий гэж Варя хэлэв.

–Арван нэгээс оройтохгүй ирээрэй гэж Нина пальтогоо товчлох зуур түүнд захив.

Түүнийг хаалга хаагаад гармагц Варя Зоя руу утасдав.

–Хүрээд ир, Нинка яваад өгсөн.

Варя ширээн дээрх юмаа эмхэлж оройн хоолоо хийчихээд сав суулгаа угааж хамаг юмаа жин тан болгов. Нинка юмыг байх газарт нь тавина гэж хэзээ ч байхгүй. Утас тасхийн дуугарлаа. Варя нүүр гарынхаа алчуурыг барьсан чигээрээ очиж утсаа авав.

–Наташа, чи юу?

Энэ бол утсаар танилцсан хөвгүүн нь ярьж байгаа хэрэг. Тэр хоёр хэн нь ч хэнийгээ үзээгүй ажээ. Хүүгийн нэр Володя, харин Варя нэрээ хэлэхээсээ татгалзжээ.

–Наташа биш биз дээ?

–Наташа л болог доо.

Тийнхүү хөвгүүн түүнийг Наташа гэх болжээ. Гэхдээ утасдах болгондоо,

–Наташа, ингэхэд чиний нэр хэн юм бэ? гэж асууна.

Хүүгийн дууны өнгө түүнд аятайхан санагдахын гадна түүнийг хэзээ ч үзэхгүй учраас бүх юмаа ярьж болно хэмээн Варя юмаа илэн далангүй ярина. Цаадах нь бас өөрөөс нь өөр ямар ч хүнтэй ингэж илэн далангүй ярьж үзээгүй гэж нотолно.

–Наташа бол цайвар үстэй байх ёстой.

–Миний үс яг цайвар.

–Нүд чинь?

–Тэнгэр шиг цэнхэр тэгсэн мөртлөө улаан шаргал.

–Тийм нүд гэж байх уу? Чи өчигдөр оройг яаж өнгөрөөв дөө?

–Маш сайхан. Нэг техникумын бүжигт очсон, дандаа румба бүжиглэхэд сайхан таарсан хөгжим тоглосон.

–Чамд атаархаж байна. Би ч хичээлээ л давтсан.

–Давт, найз минь, давт. Хичээх хэрэгтэй, эрдэм сурлага бол үр шимт идээ, үнэн найдвартай зам, харанхуйгаас гэрэл гэгээ рүү хөтлөх харгуй...

–Хоёулаа хэзээ уулзах вэ?

–Хэзээ ч үгүй.

–Гэтэл гэнэтхэн бие биедээ сэтгэлтэй болчихвол яана?

–Хаанаас даа, чи бид хоёрын үзэл бодол дэндүү адилхан юм.

–Чи өнөөдөр юу хийх гэж байна?

–Гулгуур руу явна.

–Аль?

–Үйлдвэрийн тэндэх.

–Аль үйлдвэрийн?

–Саван хадаасны.

–Намайг аваад яв, би сайн гулгана шүү.

–Би муу гулгадаг болохоор чамд сонирхолгүй байх болно. За үүрд баяртай, над дээр хүн ирлээ.

Нүүрэндээ батгатай Зоя цагаан малгайнаас гадна банзлынхаа дотуур урт шарваар өмсжээ. Нина түүнийг угаадасны газрын цэцэг гэж шоолдог аж. Зоягийн ээж “Карнавал” кино театрын билет шалгагч учраас Варя тэр хоёрыг кинонд билетгүй оруулдаг юмсанж.

–Чи яах гэж цагааныг өмсөө вэ? хэмээн Варя Зоягийн малгайг ажиглах зуур асуугаад –Чи бид хоёр чинь тохирсон шүү дээ гэв.

–Улааных нь резин тасарчихсаан. Чи улааныгаа өмсчих, чамд зохидог юм чинь.

–Цагаан цамцан дээр улаан малгай өмсөх гэж үү?! Чи миний улааныг өмс, би цагааныг чинь өмсье.

–Дандаа заавал чинийхээр болох ёстой юм уу?

–Минийхээр биш ээ, тохиролцсон ёсоороо л байя. Зоя гоморхон дал мөрөө хавчив.

–За яахав, чи үнэхээр тэгье гээд байгаа юм бол...

–Намайг тэгж гийгүүлээд яах вэ! Би гулгуур луу ерөөсөө явахгүй.

Варя шаахайгаа мулталж хаяад орон дээрээ гараад суучихав.

–Мунхаг хэрэг, за яахав, би улааныг өмсье гэж Зоя бувтнав.

–Би гулгуур руу явахгүй ээ.

Тэр хоёр хэсэг зуур чимээгүй суухад яах учраа алдсан Зоя шал дэмий юмнаас болж муудалцсандаа харамсан байв.

–Явья л даа гэж тэрээр аргадан ятгалаа.

–Түүнийг тэнд байгаа цагт би хаашаа ч явж чадахгүй.

–Чи чинь явна гэж байсан шүү дээ.

–Тэгж байсан, одоо болихоор шийдлээ.

Саша баривчлагдсанаар Варя найз охидынхоо дундаас шууд ялгарах болжээ. Тэрээр одоо найз залуус нь гэнэтхэн алга болчихоод хожим дахиад гараад ирдэг охидын нэг болжээ. Тэр залуусыг бүсгүйчүүл нь хүлээдэг, гэхдээ үнэнч бусаар хүлээвэл тэднийг хатуу ширүүн залхаан цээрлүүлдэг болой. Түүнийг Сашатай “Арбатын нүхэнд” цуг бүжиглэж байсныг бүгдээрээ мэднэ. Тэд нарын тэнд байхыг ч харсан, зодоон болсныг ч харсан. Варя одоо Сашагийн ээжид хань болж, шоронд эргэлтийн юм хүргэж өгнө...

Варя өглөө эрт явж цуваанд оочер авч жаварт зогсоход Софья Александровна дараа нь ирж тэгээд хоёулаа хамтдаа нэгэн цонх руу дөхнө. Софья Александровна хүнтэй маргаж чаддаггүйн гадна цонхны цаана сууж байгаа хүнийг уурлуулахаас айхын хамт шоронгийн урт хүйтэн ханын дагуу өглөөний таван цагаас хойш оочерлон зогсож байгаа ядарсан хүмүүст саад болохоосоо санаа зовно. Варя хүнээс айж ичихийг эс мэднэ. Тэр хоёр Сашаг хайж бүх шоронгоор явлаа. Баривчлагдсан хүний овог нэр, хаягийг бичих нэг маягтыг тэдэнд нөгөө цонхноос өгнө. Софья Александровна түүнийг бөглөөд дахин оочерт зогсож маягтаа буцааж өгөөд хариу хүлээн, хоёр юм уу, аягүй бол гурван цаг зогсоно... “Энд байхгүй...” Тэгэхээр нь Варя “Тэгвэл хаа байна?” гэж шазруун асууна.

–“Мэдэхгүй байна”.

–“Хэн мэдэж байх ёстой юм бэ? Та нар аваад явсан юм чинь, та нар л мэдэж байх ёстой доо”.

Арбатын хорооныхонд мэдэхгүй юм гэж байхгүй тул ээж нь гудамжны санал зөвлөгөөг сонсдог боллоо. Найз залуу нь Таганын шоронд сууж байгаа Новинскийн цэцэрлэгт гудамжны нэг охин дотуур цагаан хэрэглэлд зурвас яаж хавчуулж оруулдгийг үзүүлээд хоригдлууд ёотон, алимаар дарс нэрж хэрэглэдэг учир тэдэнд ёотон, алим ахиухан явуулж байх хэрэгтэй гэж хэлжээ. Софья Александровна түүний үгийг сонсон толгой сэгсрэн байв.

–Үгүй ээ, Варя минь, Сашад дарс хэрэггүй...

Софья Александровна толиотой сайхан хижээл авгай байснаа ганцхан шөнийн хооронд буурал эмгэн болж хувирчээ. Тэрээр Сашаг баривчилсан хүмүүс дээр яваад хүрчихвэл тэд нар бас ээжтэй улс юм чинь тэдний зүрх догдлон уярна гэж эхний үес боддог байжээ. Дараа нь өөр шигээ эх олныг үзсэн, тэдний дүр төрх хэний ч зүрх сэтгэлийг эс хөдөлгөх аж. Тэд нар урт оочерт зогсож байхдаа хүүгийнхээ сургийг гаргаж зовлонг нь хуваалцах өчүүхэн найдвар энэ битүү хаалганы цаана байж магадгүй хэмээн горьдож, оочерийн түрүүнд байгаа хүнд тэр хувь нь оногдчих вий гэхээс айн түгшицгээнэ.

Буутай харуул, халдахын аргагүй ханыг үзээд амьтай голтой болгон орчлонгийн агаараар

чөлөөтэй амьсгалах эрхтэй атал энэ ханын цаана тэр эрхээ хасуулсан Саша хүү нь байгаа гэж бодно. Хүүг нь ямар хувь тавилан хүлээж байна вэ? Хүүгээ юун дээр унтаж байгаа бол? гэж бодоод өөрөө нойргүй хононо. Өөрийнх нь амин сүнс, мах цус, хамгийн эрхэм нандин амьд юм болсон хүү нь шоронгийн төмөр тавган дээр бөгтийчихөөд юу идэж байгаа бол? гэхээс өөрийнх нь хоолойгоор юу ч эс давна. Балчир байх үеийнх нь толгойн үнэр дэрнээс нь гарч, бяцхан бандийн хөл нүцгэн гүйж явсан хуурай газрын үнэр шаахайнаас нь үнэртэж, хичээлийнх нь дэвтрийн бэхний үнэр ширээнээс нь ханхална.

Тэрээр Сашаг баривчлахынх нь өмнө мөрддөг байсан хүмүүсээс тааралдаж магадгүй хэмээн горьдож гудамжаар хэсүүлчилнэ. Хүүг нь ямар аюул хүлээж байгаа, юугаар гачигдаж байгааг тэд нар мэдэх ёстой. Хэрэв нөгөө даавуун пальтотой жижигхэн нөхөртэй тааралдвал ойртож очоод Сашагийн тухай асууна. Та нарын ажил чинь ийм учраас та нарт муу санасан юм байхгүй гэж хэлнэ. Тэд нэгэнт өөрсдийнхөө үүргийг гүйцэтгэчихсэн хойно одоо юу болж байх нь падгүй учраас нинжин сэтгэлтэй байж болно шүү дээ. Тэрээр Арбатаар хэсүүчлэн энэтэй талаар нь ч явж, тэртэй талаар нь ч эргэж, дэлгүүр, мухлагаар орон оочерлож байгаа дүр үзүүлэн холхино. Гэвч даавуун пальтот жижиг, нөгөө үстэй малгайт, муухай аашт өндөр гурвын аль нь ч тааралддаггүй ээ.

Тэрээр арчаагүйдээ арга барагдан гутарч, даарч бээрсээр гэр лүүгээ буцаж ирээд хоосон өрөөндөө зовлонгоо эдэлж буй өнчин ганц амьтан бурхнаа аль хэзээний хөсөр хаяж үгүй хийсэн атлаа одоо болохоор сүсэглэн мөргөж, хамгийг харагч, бүхнийг ивээгч нигүүлсэнгүй сэтгэлт тэнгэр дээдсээс Сашагийн хувь заяаг шийдэх хүмүүсийн өр зүрхийг гэсгээн уярааж өгөхийг залбиран гуйна.

Өглөө бүр шуудангийн хайрцгийн торхийх чимээнээр орноосоо босно. Тэрээр прокурорын газраас хариу ирэх буюу эсвэл аль нэгэн нөлөө бүхий нууц сайн үйлстэнээс захидал ирэхийг хүлээнэ. Бас Сашагаас өөрөөс нь захиа харна. Шоронд хамт сууж байгаад түрүүлээд цөлөгдсөн хүнээр захиа явуулж болох талтай, цөллөгөөс бол захиа хүрээд ирдэг юм. Тийм тохиолдол байсан гэж хүмүүс ярьсан удаатай. Сонин уншихдаа Сталины хөргийг тогтож харна. Даруухан хувцастай, нүднийхээ аньсгаар дөлгөөхөн үрчлээтэй, сэвгүй сэтгэлийг илтгэх ухаант амгалан царайтай дүр нүдний өмнө тодорно. Саяхан түүний тавин насны ойн баярыг тэмдэглэсэн, одоо тавин дөрөвтэй, үгүй ээ, яг өөрийн нөхөр Павел Николаевич шиг нь тавин гуравтай. Том хүү нь насаар яг Саша шиг байх, бас нэг хүү, охин хоёр бий гэсэн. Хүүхэд гэж юу болохыг ойлгож байгаа, түүнээс гадна тун саяхан авгайгаа алдчихсан болохоор ам бүлийн гацуун зовлонг бас мэднэ. Сашагийн хэрэг л түүнд хүрэх болтугай. Тэрээр хамаг найдвараа Маркт тавьж байгаа. Марк Сталинд Сашагийн тухай ярьж өгнө. Сталин түүний хэргийг шаардаж авна, аягүй бол дуудаж уулзаж ч магадгүй. Тэгвэл Саша түүнд аятайхан санагдана, Саша түүний сэтгэлд нийцэхгүй байж таарахгүй.

Павел Николаевич Москвад ирлээ. Тэрээр болсон явдалд мэдээжийн хэрэг гутарсан ч гэсэн сүйрэл гэж үзээгүй байлаа. Сашаг буудаж алахгүй, бүх насаар нь шоронд хорихгүй, манайд бүх насаар нь хорьдог ял байхгүй юм чинь. Хүүгийн нас залуу, хамаг юм өмнө нь хүлээж байгаа. Харин хөөцөлдөх хэрэгтэй нь зөв. Гэтэл зөвхөн дээд байгууллагууд л тусалбал тус болж чадна. Мань хүн дээшээ холбоо сүлбээ байхгүй. Дээшээ холбоотой нь Марк. Софья яагаад түүнийг ойлгохгүй, ойлгохыг хүсэхгүй байна вэ! Павел Николаевич наашаа ирж

явахдаа тэвчээртэй, тэр ч байтугай өгөөмөр сайхан сэтгэлтэй байна гэж дотроо бодож явсан. Гэтэл энэ залхаж гүйцсэн байшинд орж ирэнгүүтээ нэгэн үес авгай нь болж явсан энэ эмгэнийг үзээд түүний дуунд шаардах янз байгааг сонсмогцоо хэдийгээр айж эмээж байгаагаа нуух гэсэндээ тэгсэн ч гэсэн ямар ч атугай царай нь зөрүүд туулай шиг байхыг хараад мань хүн тэр даруй дахин зэвүү нь хүрч уур хорсол нь бадарчээ. Энэ л өөрөө бүх хэргийн буруутан, дүүтэйгээ нийлж энэ хоёр л Сашаг хүмүүжүүлсэн юм чинь.

Тийнхүү нэг нь уруул нь чичирч толгой нь бөнжигнөсөн буурал авгай, нөгөө нь сайхан толиотой, сахал самбайгаа мөлчийтөл хуссан, нүд нь зэвүүцэн бүлтийсэн эр хоёр өөд өөдөөсөө хараад сууж байна. Нөгөө л хулдаасан бүтээлэгтэйгээ байгаа олон жил цуг суусан ширээнийхээ ард, нөгөө л дугуй хэлбэрийн даавуун бүрхүүлтэй чийдэнгийнхээ дор сууцгааж байна. Софья Александровна ширээнийхээ хулдаасыг алгаараа түргэн түргэн илэн толийлгон суух бөгөөд энэ нь Павел Николаевичийн дургүйг хүргэнэ.

—Чи намайг албан газруудаар явуулмаар байна уу? Тэр чинь ямар ч ашиггүй, би чамд учрыг тайлбарласан. Шийдсэн хойно нь бол давж заалдаж болно. Одоогоор шийдвэр гараагүй, мөрдлөг л явж байгаа шүү дээ.

Үүнийг далимдуулж өөрийг нь буцааж ирүүлэх гэж байгаа юм биш биз?

—Чи яах гээд байгаа юм бэ? Намайг үйлдвэрээс гаргах гээ юу? Намайг тавихгүй. Би өөрөө ч гэсэн Москвад буцаж ирэх бодолгүй байна, чи үүнийг мэдэж ав! Юу гэнэ ээ?

Өөрт нь сонсдохгүйгээр зориуд нэг юм аяархан хэлэх шиг түүнд санагджээ. Гэтэл цаадах нь юм яриагүй, гагцхүү уруул нь дуу шуугүй өмгөнөн байжээ.

—Юу гээ ч үгүй... Чамайг л сонсож байна.

—Тийм дээ, чи сонсож байна... Чи ч сонсохын хажуугаар, эцэг нь байж шинжгүй амьтан, хүүгийнхээ хойноос хөөцөлдөх дургүй байна гэж бодож байгаа. Чи миний тухай дандаа ийм муухай юм боддог, тэгээд тэр муухай бодлоо хүүдээ итгүүлсэн.

Авгай урьд өмнө ч гэсэн түүний хараал зүхлийг сонсохдоо тэсэхүйеэ бэрх тарчилдаг байсан, одоо тэрхүү тарчилгаа нөмрөн ирж, түүнээс айх айдас, ялангуяа одоо хүүгийнхээ тухай, өөрсдийнхөө хүүгийн тухай ярьж байхад бүр гутамшигтай санагдах айдсаа гэтэлж чадахгүй байгаагаа дотор ширхийтэл мэдрэв. Эцгийн ярианаас Сашад дургүйцсэн аяс авгайд сонсдож, хүүгийнхээ зовлонгоос биеэ зайлуулах санаатай байгаа юм шиг санагдана. Энэ хүн гомдол саналаа одоо ийм цагт тоочиж яаж зүрхэлнэ вэ? Өөрөө ч гэсэн Сашагийнх нь амьдралын асуудал дээр хүрчихээд байхад үүнээс айж яаж чадаж байна вэ? Тэрээр эх хүн юм чинь хэнээс ч айх ёсгүй, айх эрх байхгүй!

—Хэрэв чамайг байхад түүнийг аваад явсан бол... Тэрээр их л гунигтай ингэж өгүүлэв. Гэтэл түүнтэй чанга ярихаас өөр аргагүй, түүний сонорт хүргэхийн тулд бараг хашгирч ярих хэрэгтэй.

—Тэгнэ дээ, дахиад л миний буруу, гагцхүү миний... Чи бол зовж тарчилж байгаа хөөрхий эх,

би бол үл бүтэх этгээд, завхай зайдан, согтуу хөлчүү...

Ээ бурхан минь! Ийм зовлон хүртэл энэ хүнийг өөрчлөхгүй байна, бахь байдгаараа минчийж урвайгаад, бүсгүй хүнийг даапаалж байна. Эцэг, эрэгтэй хүн хэмээн авгай түүний ирэхийг хүлээж, тусална гэж горьдож байсан билээ! Энэ хүн Сашагаас өөр юу бодож болох вэ? Түүнд өөр юм бодох эрх байхгүй. Албадаж байгаад түүний тухай бодуулна даа. Софья Александровна бичгийн ширээ рүү очиж прокурорт бичсэн өргөдлөө гаргаж ирээд,

–Үүнийг үзээд орхи! гэв.

Эцгийн царайд дургүйцэж жигшсэн байдал тодров. Энэ хэрүүлч авгай дахиад л ямар ч ашиггүй ажил хийлгэх гэж албадах нь. Энүүний өргөдөл хэнд хэрэгтэй юм, хэн түүнийг унших юм бэ?

Гэвч өргөдлийг нь уншихгүй байж чадсангүй. Түүнтэй ийм цагт хэрэлдвэл хэн хүнгүй өөрийг нь буруутгах болно. Павел Николаевич бусад хүний хувьд шударга түвшин хүн, эцэг хүн гэдгээрээ байхыг хүсжээ. Тэрээр энэ авгайд “Тэр ч байтугай өргөдлийг уншъя гээгүй” гэж хэлүүлэх шалтаг өгөхгүй.

Энэ чинь юу гээчийг биччихээ вэ!” Танд эх хүн бичиж байна... Хүүг минь надад буцааж өгөөч...” Гэнэн, нялуун, өнгөцхөн байгааг нь. “Манай шударга, нигүүлсэнгүй засгийн газарт би хандан бичиж байна”. Мөн бичив ээ... “Миний хүүд ямар ч буруу байхгүй гэдгийг би мэдэж байна”. Хэн үүнийг үнэмших юм бэ?..”Тэр алдаа хийчихсэн ч байлаа гэсэн ямар нэгэн хорон санаа байгаагүй, тэр чинь хүүхэд шүү дээ...” Хорин хоёр нас ч хүүхэд биш шүү! Бас ямар алдаа вэ? Тойруу замаар түүний бурууг нотлохын хэрэг юу байна?!

Софья Александровна Сашагийн орон дээр толгой гудайлган суугаад энэ зэмлэлийг сонсож байна. Өргөдөл ч бичиж чадахгүй тэнэг толгой шүү хэмээн нотлох гэсэндээ ёжтой хэдэр үг хэлж байгааг нь ер тоосонгүй. Тэгж л байг! Өөрөө засвал засаг, Сашад л нэмэр болж байвал яасан ч пад алга. Авгай түүний өмнө цэвэр цаас, бэхтэй тавилаа.

–Зохих ёсоор нь биччих.

Тэрээр авгай руу самгардан харж мангар авирласнаа сая ухаарав. Өргөдөл огт тус болохгүй юм чинь яаж бичсэн байх нь ямар хамаатай юм бэ? Одоо өөрөө бичих хэрэг гарлаа, гэтэл ямар ял тулгаж байгааг мэдэхгүйгээр ер нь юу бичиж болохсон билээ?

–Ингэхэд энэ байдлаар нь явуулчихсан ч болно л доо. Алдааны тухай зүйл, бас “Миний хүүг буцааж өгөөч” гэснийг хасаж болох юм. Бусдынх нь тухайд бол... Нээрэн, ингээд явуулчихаж болно гэж Павел Николаевич хэлэв.

–За, би тэгээд засчихна аа гээд авгай өргөдлөө авлаа.

Тэрээр энэнээс илүү юм ер горьдоогүй ажээ. Тэгээд ч тэртэй тэргүй Марктай ярилгүйгээр өргөдлөө явуулахгүй л дээ.

–Чи хэзээ буцах вэ?

Цаадхынх нь уур дахин шатав.

–Би маргааш ажил дээрээ байх ёстойг чи мэдэж байгаа биш билүү?

–Мөнгө үлдээж үз хэмээн авгай эрсхэн өгүүлээд эргэлтийн юм хумыг би өндөр үнэтээс авдаг юм гэв.

Мань эр золтой л хараал зүхэл тавьсангүй. Тэрээр ердийн нэгэн инженер, цалин хөлс авдаг хүн, гэхдээ мөнгөө харамладаггүй. Гагцхүү энэ хэлж байгаа аяс, шаардаж байгаа байдал л дургүйг нь хүргэнэ. Зөвхөн мөнгөний учир л мань хүн түүнд хэрэг болж байсан. Тэрээр зуун тавин рубль гаргаад,

–Илүү өгч чадахгүй гэв.

Дахиад л шөнө. Дахиад л түгжээний төмөр хяхтнаж Сашаг сэрээлээ. Өчигдрийн харгалзагч ирж мань хүн огцомхон огцомхон тоогүй олон хонгилоор дахин бэдрэв. Харгалзагчийн бүсэнд бөөн түлхүүр хуучин янзаар харжигнаж тэрээр хоригдол авч яваагаа мэдэгдэн хаалганы бариул буюу шатны хайсыг түлхүүрээр аанай л тогшлон явна. Саша энэ удаа өгсөн уруудахаа яг тоолсоор тэд нар нэгдүгээр давхарт ирснийг гарцаагүй мэдэж авав. Хонгилын адаг дахь онгорхой хаалганы цаанаас яриа хөөрөө төдийгүй инээдэм хүртэл сонсдож шоронгийнхоос өөр амьдрал ханхалж байв.

Дьяков энэ удаа түүн рүү чийдэн тусгасангүйг бодвол ийм аргыг анх танилцахдаа хэрэглэсэн бололтой. Тэрээр өнөөдөр цэргийн дүрэмт хувцсаа биш хөх ноосон цамцан дээр хүрэн пиджак өмссөн байв. Сашаг суу хэмээн сандал руу толгой дохин заачихаад өөрөө бичиж байсан юмаа үргэлжлүүлсээр. Сашаг ер анхаарахгүй, ширээ рүүгээ тонгойн бичиж байснаа бичихээ болиод эргэж уншина, тэгснээ дахиад л бичнэ. Саша тэр хоёрыг бэхний том тавиур, бас тийм том бэх уулгагч хоёр л тусгаарлаж байв. Энэ бэх уулгагчийг шүүрч аваад Дьяковын толгойг хага цохиход огт төвөг алга гэж Сашад бодогдов. Энэ сандал дээр янз янзын хоригдол суудаг юм чинь тэдний дундаас ингэчих хүн гарч мэдэх л юм. Энд бүх юмыг урьдчилан сэргийлж алхам, хөдөлгөөн бүрийг тооцоолсон хэрнээ үүнийг бодолцоогүй байна. Эсвэл эд нар тийм хэрэг хийх сачийтай хүн байхгүй гэж үздэг юм болов уу? Эсвэл бэхний саванд хүрэнгүүт ажилладаг ямар нэгэн тусгай нууц механизм байгаа юм уу? Мэдээж, эндээс хэн ч зугтааж гарч чадахгүй, гэхдээ хүн арга барагдаж цөхрөхдөө тийм хэрэг хийчихэж болно. Ямар ч атугай Дьяков үүнээс айхгүй байна. Гэвч жинхэнэ энд байцаадаггүй юм болов уу?

Дьяков юм бичсэн цааснуудаа эмхэлж аваад өрөөнөөс гарахдаа хаалгаа нээлттэй орхив. Тэрээр эсгий гуталд хүрэн өмднийхөө түрийг дарж өмсжээ. Дьяковын ингэж дулаахан хувцасласныг хармагц Сашагийн шаахайтай хөлөөс цементэн шал жигнээд явчих шиг санагдав.

Өнгөрсөн удаагийнхаас бүх юм шал өөр байлаа.

Дьяков илүү чухал, илүү яаралтай ажилтай байгаа бололтой, ийм ажилтай болохоо мэдэлгүй Сашаг түрүүлээд дуудчихсан юм болов уу гэж бодогдмоор. Эсгий гуталтай, энгийн хувцастай болохоор тун хээгүй, албархаг бус харагдах агаад элдэв цаас дэлгэсэн ширээнийхээ дэргэд Сашаг ганцааранг нь орхичихоод гараад явчихлаа. Нүсэр бэх уулгагчаар цохиод авчих вий гэж айхгүй байсан шигээ тэр ширээн дээр байгаа цааснуудаа Сашаг уншчих вий гэж айхгүй байна.

Хонгилоос хаалганы чимээ, хүмүүсийн дуу гарч Дьяков нэг хүнтэй ярьж байх нь сонсогдсоноо эсгий гуталдаа дасаагүй бололтой дүй муутайхан гишгэлсээр буцаж ирээд хаалгаа хааж ширээ рүүгээ суугаад нүднээс нь юм ухаж, өнгөрсөн удаагийн байцаалтын цааснууд байгаа нимгэн хавтсыг гаргаж ирснээ дахин юм хайн тэр нүдийг онгичих зуур Саша руу харалгүй,

—За Панкратов, өнөөдөр юу хэлэх гэж байна? гэж асуув.

Энэ асуултыг өнгөрсөн удаа тэр хоёр юун тухай ярьж байснаа санахгүй байгаа юм шиг тайван, санаандгүй, бараг нөхөрсөг гэмээр асуулаа.

–Тэгэхлээр ийм... хэмээн Саша эхэлтэл Дьяков,

–Аа-хаан! гээд хэрэгтэй цаасаа олж аваад гарлаа. Дараа нь буцаж ирээд зогсоогоороо цаасаа эмхэлж ширээнийхээ нүдэнд хийчихээд сая сууж Сашагийн хавтаст хэргийг нээв.

–За Панкратов... Миний зөвлөсөн юмны талаар бодов уу?

–Бодсон. Гэвч юун тухай яригдаад байгааг мэдэхгүй хэвээрээ л байна.

–Муу байна! гээд Дьяков толгой сэгсрэв. Дууных нь өнгөнөөс зэмлэх харамсах янз мэдэгдсэн төдийгүй дүү хүү, чи яасан өөрийгөө боддоггүй хүн бэ? хэмээн өрөвдөх янзтай өгүүлэх шиг болов.

Тэрээр хэсэг зуур бодлогоширсноо Сашагийн хэрэг бүхий хавтас руу дохиж,

–Сунжруулаад байя гэж санаж байна уу? гэв.

–Та өнгөрсөн удаа хувьсгалын эсэргүү ямар ярианы тухай ярьсныг би мэдэхгүй байна.

Дьяков хөмсөг зангидлаа.

–Панкратов, та үнэнээ хэлэхгүй байна. Та биднийг гол юмнаас хөндийрүүлж, нөгөө сургуулийнхаа явдал руу хөтөлчих гээд байна. Гэтэл та бас тэр хэргийн тухайд ч гэсэн шударга биш байсан байна лээ. Зөндөө юм нуусан байсан. Энэ ч гэсэн таныг бас тодорхойлж л байна.

–Би юу нуугаа вэ? хэмээн Саша гайхаж хоцров.

Энэ мөчид цаатан царайтай, чийрэг нүсэр биед нь хар хөх костюм нь сайхан таарсан хижээл хүн орж ирэв.

Дьяков бослоо. Сайхь хүн Дьяковыг суу гэж толгой дохиод хажуугийнх нь сандал дээр өөрөө сууж,

–Үргэлжлүүлцгээ! гэв.

Тэгээд Сашаг сайтар сонжин харлаа. Саша энэ хүн Дьяковын дарга гэдгийг ойлгохын хамт өөрийг нь зүгээр нэг мөрдөгдөж байгаа хүнийг албаныхаа дагуу сонирхох төдийгөөс арай өөрөөр харсныг түүний харцнаас мэдрэв. Тэгмэгц энэ хүн хувь заяаг нь өөрчлөх байх гэсэн горьдлого зурсхийн төрөв.

–За Панкратов, бид нар чинь юун дээр зогслоо? гэж Дьяков асуув.

–Та намайг юм нуусан юм шиг хэлсэн. Би юу нуугаа вэ?

–Үүнийг мэдэхийн тулд намын хурлын протоколыг харахад л хангалттай. Та тэр ч байтугай дээгүүр албаны хүмүүсээс дэмжлэг авах гэж оролдсон...

Дьяков Сашаг сонжих мэт хүлээзнэн харав.

За тийм байдаг байж. Бүх юм тодорхой боллоо. Марк, Будягин хоёрын аль нэг буюу хоёуланттай нь холбоотой хэрэг болж таарлаа. Саяын цухуйлгадаг зүйл ойлгомжтой. Мань хүн зориуд “дээгүүр албаны нөхөд” гэхгүй “дээгүүр албаны хүмүүс” гэж хэллээ. Бас овгийг нь ч хэлсэнгүй. Тэгэхгүй шүү, овгийг нь заавал өөрөө хэлэг. Сашагаас ямар ч байсан тэдгээр овгийг олж сонсохгүй дээ.

–Та хэнийг хэлж байгаа юм бэ?

–Панкратов!..

Дьяков жигшиж дургүйцсэн байдалтай хямсйн ярвайв.

–...Ичмээр юм, Панкратов! Бидэнтэй муур хулгана болж тоглохын хэрэг байхгүй. Бид таны бодож байгаа шиг юу ч мэдэхгүй улс биш шүү. Та биднийг албадаж яриулах гээд байна, гэтэл бид танаар яриулмаар байх юм, таныг л бодсондоо тэр шүү дээ. Рязанов, Будягин хоёр таны талаар хөөцөлдөж байсан, үүнийг та намын хурал дээр хүлээсэн, тэгсэн мөртлөө одоо мэдэн будлиад байх юм.

Бас л “нөхөр Рязанов, Будягин нар” гэхгүй зүгээр л Рязанов, Будягин хоёр гэж байна

–Би хэнээс ч ивээл эрээгүй хэмээн Саша эсэргүүцэж,

–Бүх болсон явдлын тухай би нагац ах Рязановт ярьсан, гэхдээ хөндлөнгөөс оролцоорой гэж түүнээс гуйгаагүй. Тэр надад хэлэлгүйгээр сургуулийн захирал Глинская руу утасдахыг Будягинаас өөрөө гуйсан байна билээ гэв.

–Тэгж саная хэмээн Дьяков түүний үгийг дагуулснаа,

–Тэгвэл та энэ тухай өнгөрсөн удаа яагаад яриагүй юм бэ? Яагаад чухам эднийг нэрлээгүй вэ? Та баахан хүнийг нэрлэсэн гээд хэрэг дотроос Сашагийн урьд өмнө үзээгүй нэг нарийхан цаас гаргаж ирж,

–Баулин, Лозгачёв, Азизян, Ковалёв гэж байна, гэтэл Рязанов, Будягин хоёрыг нэрлээгүй байна. Яагаад тэр вэ? гэж асуув.

Саша хүчлэн бодлоо. Одоо түүний хэлэх үг болгон Маркийн хувьд ч, Иван Григорьевичийн хувьд ч ямар ч гай тарьж мэднэ. Энэ хоёртой л холбоотой гэдэг нь тодорхой байна. Тэднийг юугаар буруутгаж байгаа юм бол?

–Холбогдолгүй гэж үзсэн юм. Энэ бол зөвхөн төрөл садны холбоо. Үүнийг та яагаад ингэтлээ шохорхож байгааг ч би огт ойлгохгүй байна.

Тэрээр энэ тухай ярих дургүй, цаашид ч хэлэлцэхгүй зүйл гэж мэдэгдэх гэсэн мэт эрсхэн тэгж хэлжээ. Дьяков түүний явах ёстой замыг зааж байна, гэхдээ Саша энэ замаар явахгүй юм чинь.

Дьяков түүн рүү анхааралтай, санаа тавьсан төдийгүй болгоомжилсон янзтай харахыг Саша мэдрэв.

–Сольц чиний хэргийг авч хэлэлцсэнийг бас нагац чинь зохион байгуулсан уу?

–Хэн ч зохион байгуулаагүй. Би өөрөө Сольц дээр очсон юм.

Дьяков жуумганан хямсайв.

–Хүмүүс түүн дээр орох гэж хэдэн сараар хүлээдэг байхад та зүгээр явж очоод л тэр дор нь таныг хүлээн авч, тэр дор нь шийдээд болчихдог гэнэ ээ. Панкратов, таны хэлж байгааг хэн үнэмших юм бэ?

–Ямар ч байсан яг л тийм юм болсон гэж Саша өгүүлээд

–Би өрөөнд нь орчихсон юм, тэгээд тэр намайг үзээд ямар хэргээр явааг асуусан... гэв.

–Азтай тохиолдол таараа юу?

–Магадгүй... ТШБК-т хүсэлт тавих эрх надад байгаагүй юм гэж үү? Миний нагац ах миний тухай хөөцөлдөх эрх байхгүй гэж үү? Энд миний буруу нь юу байгаа юм бэ? Ингэхлээр та нар намайг үүнээс болж энд байлгаж байгаа хэрэг үү? Огт яагаа ч үгүй, ямар ч гэмгүй хүнийг!

Дьяковын царай худлаа хувьсхийлээ. Гэвч юу ч хэлсэнгүй, гагцхүү мань хүн, Дьяков бээр ямар этгээдтэй зууралдаж байгааг үз дээ гэсэн шиг дарга руугаа нүдний булангаар сэмхэн харжээ. Магадгүй, даргыгаа ямар нэг юм хэлэх байх гэж бодсон ч байж болно. Гэтэл цаатан царайтай нөгөө хүн юу ч хэлсэнгүй, харин лүглийтэл босоод гараад явчихав.

Дьяков хөмсөг зангидан хэдийн дуугаа өөрчилж,

–Та намын өмнө үнэнч шударга биш байна, таны буруу тэр юм. Та өөр бас зөндөө юм нуусан. Та өөрийгөө буруутгасан бүх хүнийг нэрлэсэн. Гэтэл өөрийгөө өмгөөлсөн хүмүүсийн тухай нэг ч дурсаагүй. Уул нь таны энэ хэрэгт их олон хүн хамрагдсан шүү дээ. Наад зах нь нөгөө Криворучко гээд л бод л доо... гэв.

Саша аюул айсууг ухаарлаа. Бүх юм тун санаандгүй газар тасарч мэдэх нь. Марк, Будягин хоёрын тухайд бол асуудал тодорхой, мань хүн тэднийг буруутгах юм хэлж чадахгүй, хэлэх ч үгүй. Харин Криворучко... “Энэ тогооч хурц хоол хийх вий...” Криворучко Сталины тухай ингэж хэлсэн. Түүний энэ үгийг дурсвал Саша өөрөө шинэ юманд орооцолдохоор тогтохгүй Криворучког барьж өгсөн хэрэг болно. Чимээгүй өнгөрөх юм бол худал хэлэх, шударга бус байх замд орно гэсэн үг.

–Би түүн дээр хоёр удаа л орсон. Эхний удаа сургуулиас хөөгдсөн бичгэн дээр тамга дарж

өгсөн, дараачийн удаа нь намайг буцааж оруулсан бичиг баримтыг бүрдүүлсэн.

Дьяков инээд алдав.

–Нэг хөөгдөөд л, нэг буцаж ороод л, нэг шоронд суугаад л... Тэгээд мань хүн чамд юу ч яриагүй юу?

–Тэр их гутарсан шиг санагдсан, түүнийг чинь намаас хөөчихсөн юм шүү дээ.

–Таныг ч бас хөөсөн. Тэр танд үнэхээр юу ч хэлээгүй гэж үү дээ?

Дьяков түүнээс урьдын адил хараа эс салгана. Мань хүн ямар нэг юм мэдэж таамаглаж байна уу, эсвэл тандаж байна уу, аягүй бол өөрийнх нь самгардаж байгааг мэдчихэв үү?

–Таныг сургуулиас хөөчихөөд буцаад авч байхад тэр тухай үнэхээр санал бодлоо хэлсэнгүй гэж үү дээ? хэмээн Дьяков өөрийнхөөрөө зүтгэж,

–Үгүйдээ ганц юм ч асуусангүй гэж үү? Намын товчоон дээр та түүнийг өмгөөлж байсныг ч бодсон юм хэлмээр л юм гэв.

–Би зүгээр л юу болсныг ярьсан юм...

-- За тэр дээ... Тэгээд цаадах чинь тамгаа зүгээр дарчихаа биз.

Үгүй ээ, энүүний аяыг дагаж болохгүй! Энэ чинь өөрийнх нь янзыг үзэж, элдвээр сорьж, гол юмнаас, Марк, Будягин хоёроос анхаарлыг сарниулж, орооцолдуулж байна...

–Ямар ч онцгой яриа болох үндэс байгаагүй. Тэр чинь орлогч захирал, би бол жирийн нэг оюутан.

Дьяков түүнийг нэвт сүлбэх мэт харлаа.

–Гэтэл Криворучко бусад оюутантай намын эсрэг яриа явуулсан тухай мэдээ бидэнд бий. Тэгсэн чинь тан шиг гомдсон хүнд бас тэгээд өөрийг нь хамгаалж байсан хүнд юу ч хэлээгүй гэнэ. Хачин юм даа!..

Криворучко Марктай танил, түүнд мэнд дамжуулж байсан. Үгүй ээ, энэ тухай ярьж болохгүй.

–Хэлээгүй л юм гэж Саша өчив.

Дьяков Сашагаас хараа салгахгүй байснаа гэнэтхэн бах нь ханах мэт малилзаад явчихав. Тийнхүү тавласан янзтай инээмсэглэсэн чигээрээ байцаалтын цэвэрхэн хуудас өөр лүүгээ болголоо.

–За яахав, бид бол тэвчээртэй улс. Таныг санавал зохих юмаа санатал шударга байя гэж шийдэхийг чинь хүртэл хүлээе.

Дьяковын энэ удаагийн бичсэн зүйл “Үүний өмнө миний өгсөн мэдүүлэг дээр нэмэх нь...” гэсэн үгээр эхлээд Саша Криворучкогийн өрөөнд ордог байсны гадна намын товчоон дээр түүнийг хамгаалж байсан, харин Янсон, Сиверский хоёр Сашаг өөрийг нь хамгаалж байсныг хүлээн зөвшөөрсөн тухай бичсэн байв. Марк, Будягин хоёрын тухай энэ протоколд нэг ч үг алга.

Бүх юм зүйтэй бичигдсэн боловч бас л түрүүчийн удаагийнх шиг ямар нэг юм бүүр түүрхэн айдас төрүүлнэ. Энэ аюул чухам юунд байгааг тэрээр ухаарч чадсангүй. Тэгээд зөвхөн Криворучко дээр ажлаар очиж байсан гэж нэмэхийг шаардав.

–Та оюутан хүн, ажлаар очиж байсан нь мэдээж шүү дээ.

“Чөтгөр авмар!” гэж бодоод Саша протоколд гарын үсэг зурлаа.

–Би ээжээсээ эргэлт авахгүй байгаа болохоор санаа зовох юм. Түүнээс гадна надад номын сангаас ном сонин өгч байхыг хүсье.

Дьяков толгой сэгсрэв.

–Мөрдлөг явж байхад энэ мэт зүйлийг ерөөсөө зөвшөөрдөггүй юм. Та хэрвээ үнэнээ ний нуугүй ярьдагсан бол та бид хоёр юмаа дуусгаж цэглээд, тэр цагт та саяынхаа хүсэж байгаа юмыг саадгүй авч болохсон. Түүнээс гадна, Панкратов, бидний дараачийн уулзалт сүүлчийнх болно гэдгийг бодоорой гэснээ тэрээр хуруугаараа тааз руу зааж,

–Надаас бас шаарддаг юм шүү дээ. Би бол ч энэ хэргийг танд л ашигтайгаар дуусгамаар байна. Энэ бололцоог битгий алдаарай гэв.

Эсвэл Марк, эсвэл Иван Григорьевич, эсвэл хоёулаа хамт даа. Шударга, намдаа үнэнч коммунистууд! Тэрээр Будягиныг бага мэднэ, харин Маркийг сайн мэдэх учир түүнд бүрэн итгэж ямар нэгэн муу юм бодохыг эс түвдэнэ. Маркийг баривчилсан бол өөрийг нь барьсны адил эндүүрлийн хэрэг. Гэхдээ мань хүн бол сургууль дээр болсон золгүй явдлын эзэн, харин Маркт ямар ч буруу байхгүй тул түүнийг барьсан бол бүр ч эндүүрэл байх ёстой. Марк мундаг инженер, аж ахуйн гарамгай ажилтан, өгөөмөр сэтгэлтэн, жинхэнэ коммунист, тэгээд ч бүхий л амьдрал нь ажил, гагцхүү ажлын төлөө зориулагдсан юм чинь түүнээс юу ч олох ёсгүй. Түүнийг шоронд хийчихлээ гэж үү? Аягүй бол мань хүн энэ хавьд, яг энэ хонгилд, бүр дэргэд байж байгаа юм биш биз? Нүд харалган, зүрх муу Марк энд, яг ийм өрөөнд байх хэрэг үү?

Саша Маркийн ямар ч бурууг мэдэхгүй, түүний үнэнч шударга гэдэгт итгэл төгс байна. Тэгэхлээр мань хүнийг Рязановыг хаацайлж байна гэж үзвэл үзэж л байг! Саша Маркийн зовлонг хуваалцахад бэлэн юм чинь. Юмны ая ингэж таарч, ингэж нөмөрч ирсэн хойно яая гэхэв, тэсвэрлэж өнгөрөөх хэрэгтэй, цаг нь болохоор өөрөө ч гэсэн, Марк ч гэсэн буруугүй гэдгээ нотлох л болно.

Бүх юм тодорхой байна, толгойгоо зовоохын хэрэггүй боллоо. Тэрээр намын өмнө үнэнч шударга байна, юу ч нууж хаагаагүй, Маркийг муулж чадахгүй. Гүйцээ. Цэглэе.

Зөвхөн нэг юм санаа зовооно... Криворучко... Найдвар байхгүй эмээж байгаа ганц юм энэ. Ямар ч байлаа гэсэн юм нуусан нь үнэн. Тэр нь магадгүй нэг их чухал биш яльгүй зүйл байж болно, гэхдээ л ямар ч атугай нуусан. Мань хүн сэтгэлдээ сэвгүй байхсан гэж санана. Гэвч Криворучко хиргүй тунгалаг сэтгэлд нь одоо сэв боллоо.

Өдөр нь ганц хуудас, харандаа хоёр барьсан нэг танихгүй хянагч хүрч ирэв.

–Номын санд захиалга бичээрэй.

Номын санг зөвшөөрчээ! Хичнээн ном, ямар хугацаагаар авч болохыг Саша даанч мэдэхгүй. Гэвч юм мэдэхгүй гэдгээ ер харуулсангүй. Шоронгийн албаны хүмүүс туршлагагүй хоригдлоос туршлагатайг нь илүү тоодог билээ.

Толстой - “Дайн ба энх”, Гоголь - “Амьгүй албат нар”, Бальзак - “Арилсан мөрөөдөл”, Стендаль - “Пармын орон суурин”, “Красная новь”, “Новый мир”, “Октябрь”, “Молодая гвардия”, “Звезда” сэтгүүлүүдийн сүүлчийн дугаарууд... хянагч хүлээгээд бодох цаг байхгүйг ч хэлэх үү, хоригдол хүн өөрт нь юу хэрэгтэйгээ урьдаас шийдсэн байх ёстой, тийм учраас мань хүн элдвийг бодож түгдрэлгүй толгойдоо орж ирснийг л хуу бичжээ. Гол нь ном олж авах нь чухал, гэхдээ дараачийн удааг хүртэл бүрэн хүрэлцэхээр аль болохоор зузаахан номтой болох хэрэгтэй. Бас тэгээд тэр дараачийн удаа гэдэг нь хэзээ болох нь бүү мэд юм чинь.

Харин зөвхөн нэг номыг зориуд бичив. “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”. Тэр номыг өгөхгүй л дээ. Тэглээ ч гэсэн мань эр “ЗСБНХОУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль” хэмээн бичиж, тийнхүү ийм байдалд байгаагаа эсэргүүцэл илэрхийлсэн шүү юм болжээ.

Ном авахыг Дьяков яагаад зөвшөөрөх болов? Урмыг нь сэргээх гээ юу? Уул нь Сашаг энд тэсэхүйеэ бэрх байлгаж үнэнийг нь албадан хэлүүлэх сонирхолтой баймаар юм. Ном өгөх ёстой хууль байдаг бол түүнийгээ зөрчихөөс айгаа юм болов уу? Өрөвдөв үү? Хувьсгалын эсэргүү хэргээр баригдаад байхад өрөвдөнө гэж хэзээ ч байхгүй. Эсвэл нөгөө ээлж харгалзахгүй усанд оруулдаг шиг энэ ч бас Дьяковоос гадуур болж байгаа хэрэг юм уу? Харамсалтай юм. Буруу юм болсныг олж тогтоогоод мань хүнд ном өгөхгүй болчихно.

Гэтэл маргааш өдөр нь шарласан түлэнхий оромтой цэвэрхэн цагаан даавуунд ороосон боодолтой юм барьсан шинэ хянагч хүрч ирэв. Саша энэ боодлыг гэртээ өмдөө индүүдэхдээ давхарлаж тавьдаг байсан даавуу мөн гэдгийг дор нь танилаа. Тэгэхлээр ном төдийгүй эргэлт оруулахыг бас зөвшөөрсөн байх нь.

–Овог?

–Панкратов.

–Гарын үсгээ зур.

Хянагч түүн рүү эргэлтийн юмны жагсаалт, харандааны өөдөс хоёр сарвайв.

Юмны жагсаалт ээжийнх нь гаргац муутай саргар бичиг мөн байх бөгөөд ганцхан “шоколад” гэдэг үгийг тодхон бараг уран гоёор дурайтал бичсэн танихгүй бичгийн хэв байх ажээ. Жагсаалтын тэн хагасыг хортой харандаагаар сараачжээ.

Ээж нь гардан нямбай өрсөн боловч хожим бусдын гараар орж замбараагүй болсон ууттай юмс, боодол тэргүүтнийг Саша ширхэгчлэн үзэв... Цагаан загасан талх, бяслаг, чанамал мах, хиам, энэ тэрийг шалгахдаа бүгдийг нь огтчиж хэрчсэн байхыг мэдэв. Тэдгээрээс гадна пергамент цаасанд боосон цөцгийн тос, ёотон, солих дотуур хувцас, оймс, нусны алчуурууд энэ тэр байна. За ингээд ээж нь амьд сэрүүн, өөрийг нь хаа байгааг мэдэж байгаа юм байна, тэсэж дээ,

–Хуучин дотуур хувцсаа буцааж болох уу?

–Боочих.

Тэрээр бохирдсон хувцсаа нөгөө даавуунд боов. Индүүнд түлэгдсэн цагаан даавууны энэ тасархай түүнд айлын үнэр, өөрийнх нь орон гэрийн үнэрийг авчирчээ.

–Хүсэж байгаа юмаа биччих.

Саша жагсаалтын ар дээр “Бүх юмыг авлаа. Цагаан талх, мах, дотуур хувцаснаас өөр юу ч ирүүлэхийн хэрэггүй. Бүх юм сайн, би эрүүл байна, үнсье. Саша” гэж бичив.

–Харандаа! гэж хянагч шаардав.

Хүүгийнх нь гунигт хувь заяа, зовлонг илэрхийлсэн тэмдэг төдийгүй түүний амьдралыг илтгэх тэрхэн цаасны тасархайг Софья Александровна барилж имэрч үзэхийн хамт арав, зуу, мянга дахин унших бүлгээ. Тэрээр Михаил Юрьевич, хөрш бүсгүй Галя, Милица Петровна, эгч дүү нар, Варя Иванова, Макс Костин энэ тэр гээд бүх хүнд тэр цаасаа үзүүлнэ... Юу ч хэрэггүй, бүх юм сайн, би эрүүл байна, үнсье... Ийм зүйлийг гагцхүү хүү нь л, цайлган сэтгэлтэй эрэлхэг зоригтой тэр хөвгүүн л бичиж чадна.

Одоо бүх юм шинэ утга агуулгатай боллоо. Үүнээс өмнө хүүгээ амьд гэж төсөөлөн бодоход энэ үнгэлдсэн зурвас, шоронгийн үнэр шингэсэн дотуур хувцас, хүүгийнх нь захисан мах, талх мэтийн үзэж харж болох тодорхой юм үгүйлэгдээд байсан юмсанж. Үдэш орой, шөнө эзэнгүй хоосон оргидог нь больж хүүтэйгээ хамт байх шиг санагдан түүний минут нэг бүрийг, хөдөлгөөн болгоныг мэдээд байгаа гэлтэй болжээ... Өөрийнх нь зүрх өвдвөл хүүгийнх нь бие тавгүй байгаа хэрэг, нойр нь хулжчихаад байвал хүү нь орон дээрээ нүдээ хараад хэвтэж байгаа хэрэг, дотор балартам айдас хүрч байвал хүү нь байцаагдаж байх суух газар олдохгүй зовж тарчилж байгаа хэрэг гэж санана. Тэрээр хүүгээ нэг удаа шийтгэснээ нэхэн дурсана. Хүү нь театрт явуулахгүй гээд байсан. Тэгэхэд нь загнаад үлдээчихсэн, хүү нь өвдсөндөө биш доромжлуулсандаа болоод уйлсан. Тэр жижигхэн амьтныг тэр үед эх өөрөө доромжилжээ. Тэгтэл одоо түүнийг амьдрал доромжилж байна.

Марк Сашагийн тухай дээгүүр албаны нэр нөлөө бүхий хүмүүстэй ярьсан. Тэрээр элдэв үгээр хуурч худлаа тайвшруулаагүй, чадах бүхнээ л хийсэн, түүнд итгэлгүй яахав. Тэглээ ч гэсэн шоронгийн оочерт зогсож байгаа хүүхнүүдийн үгэнд Маркийнхаас илүү үнэмшдэг байлаа. Тэнд бүх юм тодорхой, энгийн бөгөөд шударга байдаг. Энэ хөөрхий эмэгтэйчүүд ойр дотныхоо хүмүүсийг яаж ийгээд хамгаалж байгаа билээ. Жаварт зогсоод алдаж байгаа биеийнхээ бүлээнээр тэднийгээ дулаацуулж, хомсхон хоол хүнснээсээ илүүчилсэн өчүүхэн юмаар тэднийхээ өлөн голыг зогоож, битүү чулуун ханыг нэвтлэн хайрлах сэтгэл, итгэл найдвараа тэдэндээ илгээнэ. Софья Александровна шоронгийн тэнд ганцаардмал байдлаасаа ангижрах шиг болдог тул шоронгийн оочерын тухай бодохдоо айхаа больжээ. Үүнээс болж сэтгэлийн зовлон багасаагүй ч гэсэн арга барагдан цөхөрдөг нь эрхбиш намджээ. Тэрээр бусдын хийдгийг л хийх ёстой. Урьд өмнө жигтэйхэн аймаар санагддаг байсан ертөнц одоо түүнээс гар хумхин зүгээр суухгүй байхыг шаардаж байна. Гэтэл юм хийнэ гэдэг чинь айдсыг дардаг ажээ. Сашаг яаж эрж олох, эргэлт яаж оруулах, юу оруулах, хааш нь хүсэлт тавих, хэнд юу бичих энэ тэрийг хүүхнүүд түүнд зааж өгчээ. Чухамхүү тэдний зөвлөсөн газар руу санал хүсэлтээ бичих ёстой байлаа. Тэрээр Улс төрийн ерөнхий газрын байгууллагуудыг хянах прокурортой уулзаж чадсан байна. “Мөрдлөг дуусахаар та үр дүнг нь мэдэх болно” гэж хариу өгдөг хэмээсэн хүүхнүүдийн үг үнэн болсон ч гэсэн энэ хариу чухал зүйл юм. Яагаад гэвэл одоо прокурор Сашагийн хэрэгт анхаарал хандуулна, энэ бол их юм өөрчилж мэдэх талтай. Хэрвээ Сашаг яллан шийтгэвэл юу хийх хэрэгтэйг оочерийнхон мэднэ, тэд бүх замыг мэднэ, энэ зам бол бас л амьдралын зам, хүмүүс тэр замыг туулаад л байгаа, тэгж бодохлоор энэ бүхэн нөгөө амлалт, горьдлогоноос илүү сэтгэл тайтгаруулна. Сашаг хааш нь явуулах нь мань хүн эмчийн үзлэг хийхийг шаардах ухаанаа олох эсэхээс хамаарна, тэрээр мөгөөрсөн хоолойн архагтай учраас Сибирьт биш Волга дагуух нутагт заагдаж болох үндэстэй. Хэрвээ Софья Александровнад утасдаад дулаан хувцсыг нь бэлтгээрэй гэж хэлбэл Сибирь юм уу Умард зүгт,

юм эс хэлбэл Дундад Ази руу хүүг нь явуулах болсон гэсэн үг.

Сашагийн өрөөг түгжиж лацдана, байрны даргад өөрт нь бодвол эвгүй л байдаг байх, гэвч үүнийг тэр л хийх үүрэгтэй гэж Софья Александровна дуулсан болохоор нэг удаа байрны дарга Виктор Иванович Носовыг хүрч ирэхэд тэрээр гайхсангүй. Гагцхүү цаадах нь санаа зовсондоо болоод ширүүлж магадгүй гэж эмээж, хэрэв тэгвэл хэлнэ гэж зориуд үг зэхсэн байжээ.

Тэрээр “Виктор Иванович, та надтай тайван яривал би илүү ойлгох байх” гэж хэлэх санаатай байжээ.

Гэвч Виктор Иванович ширүүлсэнгүй,

–Ийм журамтай юм, Софья Александровна минь. Цаг нь болохоор онгойлгоод л өгнө. Танд ч амар шүү дээ. Манайхны ардуудыг та мэднэ, нэг орчихвол гарна гэж байхгүй дээ. Ямар нэг юм нааш нь цааш нь зөөх бол би хашаачныг ирүүлчихье. Хэрэг болохгүй юмнуудаа үлдээчих, таны л өрөө юм чинь.

Тэрээр нөгөө өрөөнөөс бүх юмыг гаргах хэрэггүй гэдгийг Софья Александровнад ойлгуулж байгаа нь тэр ажээ. Өрөөнд эд юмс байгаа цагт түүнийг хэн ч дур зоргоороо эзэгнэж авч чадахгүй гэдгийг Софья Александровна өөрөө ч бас ойлгож байжээ. Харин хашаачнаар туслалцуулахаа болихоор шийдэв. Түүнд мөнгө төлөх хэрэгтэй болно, гэтэл өөрт нь мөнгө байх биш. Тэрээр Сашагийн унтдаг, хичээлээ хийдэг дундын өрөөг биш, өөрийнхөө унтлагын өрөөг чөлөөлөв. Тэндээс өөртөө хэрэгтэй бүх юмыг гаргаж, тийш нь Сашагийн бичгийн ширээ, буйдан, өлгүүр энэ тэрийг оруулах хэрэг болов.

Ийм ажилтай байхад нь Варя яг орж ирэв. Тэрээр пальтогоо бушуухан тайлаад авгайд тусалж хураалттай цагаан хэрэглэл, даашинз, жижигхэн хивс, дэр, хөнжил сэлтийг нь унагаж сандаалгүй зөөлөө. Хааш нь хийхийг яг мэдэхийн хамт сайхан эмхлээд бүгдийг нь багтаагаад хийчихлээ.

Энэ охины туслалцаа Софья Александровнад аятайхан санагдахын чацуу охин өөрөө ч бас аятайхан санагдана. Варяг өөрийнхөө амьдралд оролцуулж, зовлонгоо нялзаах нь дэмий юм болж байгаа байх гэж Софья Александровна заримдаа бодовч Варягийн өрөвдөж байгаа байдал, туслах гэсэн эрмэлзэл нь үнэхээр үнэн санааных байсан тул түүнийг чухам яаж оролцуулахгүй байхаа өөрөө үнэндээ төсөөлөхгүй байлаа.

Одоо ч гэсэн энэ охины тусалж байгаа нь тэр хоёрын ажлыг гэр орноо зүгээр л янзалж, тавилга энэ тэрээ сэлгэн тавьж байгаа мэт харагдах бөгөөд Софья Александровна энэ байдлыг өөрчлөхгүйн тулд түүнд юу ч ярьсангүй. Харин өөрийнх нь зориг тэвчээр мохож байгааг мэдрэн байв. Нөхөр нь салаад явчихсан, хүүг нь бариад авчихсан, одоо нэг өрөөг нь салгаж байна... Энэ өрөөг аль хэзээний Сашад өгчихдөг байж л дээ. Нас бие гүйцсэн эр хүн дундын өрөөнд эв дүй муутай байсан, гэтэл өөрөө тав тух алдахгүй гээд өрөөгөө өгөөгүй билээ. Яасан муухай хар амиа бодсон хэрэг байж вэ? Гэтэл нөгөө даруухан хонгор хөвгүүн нь энэ тухай өөрөө эхэлж яриа үүсгээгүй.

Төмөр ор нь салж өгдөггүй, шүүгээнийх нь нэг хөл хугарчихлаа, татуургануудыг сугалж авсан боловч өөрийг нь байрнаас нь хөдөлгөж чадсангүй.

Михаил Юрьевич ажлаасаа ирж хөршийн Галя хүүхэн энэ тэр нийлж байгаад шүүгээгээ зайчилж, төмөр ороо салгаж, Сашагийн унтдаг буйдан, түүний бичгийн ширээ, номын тавиур гурвыг жижиг өрөө рүү оруулав. Софья Александровна бичгийн хэрэглэлийг эвлүүлэн байрлуулж Сашагийн хэдэн номыг тавиад хөшгөө зүүлээ.

Максын шинэ жилээр дагуулж ирсэн нөгөө Серафим гэдэг залуухан сонсогч гэрт нь хүлээж байгааг Варя мэдсээр байсан хэрнээ бүх ажлыг нь дуусгаж байж сая Софья Александровнагийнхаас явлаа.

Энэ Серафим тэр үедээ тэгээд алга болчихоогүй, ерөөсөө л маргааш нь утасдаж Арбатын талбай дээр уулзах болзоо тавьжээ. Варя зүгээр л тоглоом болгож тийшээ очихоор шийдээд Зояг бас нэг охинтой хамт дагуулаад явжээ. Хоёр найз нь гудамжны нөгөө талд үлдээд Варя руу нэгэн залуухан цэргийн хүн очиж Арбатаар дагуулан явахыг харцгаав. Хоёр охин гудамжны нөгөө талаар бараадан явж Варя руу янз янзаар дохивч цаадах нь ойлгодоггүй, цаадхынхаа хариу дохиог мань хоёр бас ойлгодоггүй гэнэ. Серафим түүнийг Улаан Армийн ордонд бүжигт урьжээ. Варя кино үзэх гэж байсан тул тэр орой чадсангүй. Гэвч Улаан Армийн ордонд орох хичнээн хэцүү гэдгийг тэрээр мэдэх тул дараачийн хагас сайн өдөр тийшээ явья гэж Серафимд амласан аж. Серафим орчин үеийн бүх бүжгийг бүжиглэдэг тул тэр хоёр тийшээ долоо хоног алгасахгүй явах болж найз охид нь Варяд атаархдаг байжээ.

Варя залуугийн инээдтэй нэрэнд дасаж санаанд орохоо больжээ. Алдарт тамирчин ах дүү хоёр Знаменскийн нэгийг бас Серафим гэдэг билээ. Серафим тэдний хашааны төрөлхийн Москвагийн, төрөлхийн Арбатын банди нартай адилгүй нь мэдээж, тэр бол хөдөөгийн нүүр хагараагүй хөвгүүн. Гэхдээ мань хүн түүнийг үнэнээсээ эргүүлж байгаа нь Варягийн бахыг ханган дэвэлзүүлж тэрээр том хүн болчихсон шиг санагдана. Түүнээс гадна Серафим Максынх нь найз юм чинь, Макс бол муу найзтай байх ёсгүй болохоор Нина эгч нь тэр хоёрын үерхлийг буруушаах юм олоогүй билээ.

Варяг гэртээ ирэхэд Нина ууртай харцаар угтав. Серафим цаг хэртэй ном эргүүлж буйдан дээр байх суух газраа олж ядаж байгаагийн гадна номынх нь хуудас шажигнан, сурагчдын дэвтэр засаж байгаа Нинагийн ажилд саад болж байсан ажээ. Тэгэхлээр түүний загнасан харц бол “Чи хүнтэй тохирсон шүү юм бол цагтаа ирж бай, чиний харчуулыг саатуулж байх үүрэг надад байхгүй” гэсэн үг юм.

Варя яагаад хожигдсоноо эгчдээ учирласангүй. Хэлнэ, гэхдээ сүүлд хэлнэ. Харин одоо бол хувцсаа сольж өмсөх хэрэгтэй байсан тул Серафимийг хонгилд гарзнаж бай гэв.

Хувцасны шүүгээний хаалганд өлгөөтэй толь руу хараад зогсоход гэрэл яг ар талаас нь биш хажуу талаас нь тусаж байхаар тааруулж шүүгээний хаалгыг хагас онгойлгоод хувцсаа сольж эхлэв. Аятайхан даашинзтай байж түүнтэйгээ явахгүй, бас солиод хэмээн Нинагийн дургүй хүрлээ. Үгүй тэр оймсоо өмсөж байгааг нь! Хөлөө жийж зогтусаж хараад өөрөөрөө бахархаж байна. Бас энэ хувцсаа өмсөж гүйцээгүй байж нүцгэн шалдан өрөөн дундуур явдаг маяг бас хаанаас сурчихаа вэ? Арван зургаахан настай гэж байгаа шүү!

–Чамайг хүн хүлээж байгааг битгий мартчихаарай.

–Тийм хэмээн Варя товчхон хариулснаа,

–Чи өнөөдөр надад шаахайгаа өгөхгүй юу? гэж мөн товчхон асуув.

Нина гоёлынхоо ганц шаахайг өгөх дургүй байсан боловч Варяг бушуухан зайлаасай гэхээс тэсэж ядаж байв.

–Ав.

Варя шаахайг олж, зөндөө удаан сонжин харж барилж үзсэнээ өмссөн хойноо дахин тал талаас нь харж, хөлөө жийж үзэн бас л бахдал болгов. Тэгж тэгж энэ ажлаа сая нэг юм дуусгаж хаалга онгойлгоод,

–Серафим, ор, ор гэв.

Пальтогоо өмсөж, алчуураа зангидаад нэгэнтээ тольдсоны дараа сая эгч рүүгээ эргэж,

–Би Софья Александровнагийн дунд байсан юм. Юмнаас нь зөөлцлөө. Сашагийн өрөөг лацадчихсан гэж өгүүлэв.

Варя Нинаг чадчих нь энэ. Сашагийн гэрт юу болж байгааг хүртэл Нина түүнээс олж мэднэ гэдэг бол бүр сайн чадуулсан хэрэг.

Нина ч бай, өөр хүн ч бай, хэн ч Сашад тусалж чадахгүй нь мэдээж. Тэд юу хийж чадахсан билээ? Түүнийг ямар хэргээр буруутгаж байгааг нь мэдэхгүй юм чинь! Тэглээ ч гэсэн өөрөө эрх чөлөөтэй, Саша шоронд байгаа учраас Нина түүний өмнө буруутай. Тэд нараас хамгийн сайн нь тэр шүү дээ! Гэтэл бусад нь цөмөөрөө дуугарахгүй юм. Нина энэ эндүүрлийн учир нь олдоно гэж найдаж байсан, гэтэл өрөөг нь лацадчихсан байна, ингэхээр суллахгүй гэсэн үг. Тэгэхлээр яах болж байна? Саша Зөвлөлт засгийн дайсан гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэг үү? Түүнийг таньдаг мэддэгээ болих уу? Тэд нар Сашаг зовлонд хаяж урвацгаасан байна. Нина Софья Александровнагийн дунд нэг удаа очиж харамсал илэрхийлж байсан, гэвч түүний энэ харамслаар хүн яах вэ дээ!

Захиа бичье... Саша тэдний комсомолын үүрийн нарийн бичгийн дарга байсан юм чинь түүнийг батлан дааж байна гэж бичээд нөхдийнхөө гарын үсгийг цуглуулъя. Макс гарын үсэг зурна, бас Вадим, Лена гээд бусад нөхөд ч зурна. Сургуулийн захирал, Сашаг мэдэх багш нар бас зурна. Нина Сашатай хамт суралцаж байсан өөрийнхөө сургуульд багшилдаг учраас гарын үсэг цуглуулж чадна гэж найджээ. Юрка зурахгүй, тэр муу яахав. Тэрээр Лена, Вадим хоёрт утасдаж маргааш Ленагийн дунд уулзахаар тохиролцов. Дараа нь доошоо бууж Максын ээжтэй уулзаж, хүүгээ маргааш чөлөөгөөр ирэхээр нь өөртэйгөө уулз гэж хэлэхийг захилаа.

Урамгүйхэн уулзалт боллоо. Лена юу ч ярихгүй алчуураараа өөрийгөө ороож тумлайдан сууна. Захидалд гарын үсэг зурах хэрэгтэй бол бололгүй яахав гэх царайтай. Бас Макс ч урамгүй царайлна. Тэрээр тэдний захидал ямар ч ашиггүй гэдгийг мэдэхийн гадна ингэсний

үр дагаврыг ойлгож байлаа. Гэвч айж байна гэж Нинаг бодох вий хэмээн дургүйцэхийг бодсонгүй. Ганцхан Вадим ингэж өгүүлэв.

–За найзууд аа, тийм захиа ямар ашиг өгөх вэ? Сашад нэмэр болох уу? Харин ч нэрмээс болж, хэргийг хүндрүүлбэл яана? Биднийг дуудаж, Панкратовын тухай юу мэдэх вэ? гэхчлэн байцаана. Тэр чинь сургуульд байхдаа комсомолын сайн л гишүүн байсан. Гэтэл бид түүнтэй хамт аль зургаан жилийн өмнө хамт сурч байсан шүү дээ. Тэр одоо ямар болсон бэ? Тэдний сургууль дээр юу болсныг та нар мэдэж байна уу? Тэр та нарт ярьсан уу? Юу гэж ярьсан бэ? За тэгээд дараа нь Сашаг дуудаж “Та өөрийнхөө нөхдөд юу ярьсан бэ?” гэж асууна. Сашагийн үнэнч шударга гэдэгт би эргэлзэхгүй байна. Би зүгээр л энэ бүхэн ямаршуухан янзтай харагдах вэ? гэдгийг л төсөөлье гэж бодсон юм.

–Сашагийн хувь заяаг зөнд нь орхих уу? гэж Нина асуув.

–Яагаад зөнд нь байх билээ? Хэргийнх нь учрыг олж байгаа шүү дээ. Тэгэхлээр учрыг нь олохгүй гэж үзэх ямар үндэс бидэнд байна? Бид нар Сашаг мэднэ гэдэг үнэн л дээ, гэтэл тэд нар бас тодорхойлолтыг нь шаардаж аваа байлгүй. Түүнээс мань хүнийг Саша Панкратов гэдэг болохоор нь баривчлаагүй, ямар нэг хэрэг хийснийх нь учир баривчилсан байж таарна. Харин бид тэр хэргийг нь мэдэхгүй байна.

–Бид түүнийг дэмжих ёстой гэж Нина хэлэв.

–Чи сийрэгхэн бодох хэрэгтэй шүү хэмээн Вадим зөрж,

–Саша бидний захианы тухай сураг ч сонсохгүй. Харин бид нарын тухай түүнээс толгой дараалан байцааж, тэгж гэмээ нь мань хүний байдал бүр л төвөгтэй болно гэв.

–Чиний тухай асууна гэж айгаа юу?

–Би юунаас ч айгаагүй гээд Вадим час улайв. Вадимын зөв гэдгийг цөмөөрөө ойлгож байв. Нина ч ойлгож байлаа. Гэхдээ энэ ойлгож байгаагаас арай эрхэм, арай дорвитой нэг юм байх. Бас өөр нэг гачлантай ичгүүртэй юм бий. Тэр нь тэд өөрсдөдөө төвөг удахаас айж байгаа явдал юм. Тэгээд энэ айдсыг гэтлэн давах нь захиа явуулахаас төвөгтэй байлаа.

–Аавтай зөвлөлдвөл яах вэ? гэж Лена өгүүлэв.

–Зүйтэй! хэмээн Нина түүний үгийг өлгөн авахдаа Иван Григорьевич энэ асуудалд оролцож Сашад тус болно гэж нууцгайхан горьдсон ажээ.

Энэ санаа Вадимд бас аятайхан санагджээ. Тэрээр тийм болчимгүй захидал бичихийг Иван Григорьевич хэрэггүй гэж хэлнэ гэж санажээ. Мань Вадим тэртэй тэргүй захидалд гарын үсэг зурахгүй, үүнийг тэр хатуу шийдсэн. Гагцхүү тариачин хүний хэрсүү ухаантай Максим л Иван Григорьевичийг тэгж зовоохын хэрэггүй гэдгийг ойлгож байв.

–Хэрэг байна уу даа, бид өөрснөө л шийдэх ёстой гэж Максим тээнэгэлзэн өгүүлэв.

–Гэхдээ зөвлөж болно шүү дээ гэж Нина зөрөв.

Цай уухын үес Иван Григорьевич, Ашхен Степановна хоёр зоогийн өрөө рүү орж ирцгээв.

–Аав аа, Сашаг яах вэ? гэж Лена өгүүлэв.

–Харин юу хийж болох байна?

–Бид нар Улс төрийн ерөнхий газар захиа бичье гэж байна.

Будягин хөмсгөө зангидав.

–Та нарын захидал хэнд хэрэгтэй юм бэ?

–Ямар нэг арга бодох хэрэгтэй шүү дээ гэж Нина өгүүлэв.

–Та наргүй учраа олцгооно гэж Будягин ширүүн хэллээ.

Иван Григорьевич тэр болгон бичиг цаасаар мэдээлж болдоггүй, түүнээс гадна өнөөгийн олон улсын байдлаас үзэхэд хойш нь тавьж болшгүй олон зүйлийг хэлж чадах байсан боловч түүнийг хилийн чанадаас буцаж ирснээс нь хойш Сталин нэг ч удаа хүлээж авсангүй. Уул нь Будягин уулзъя гэж гуйсан. “Та хүлээж л бай, аяндаа дуудна” гэгцгээнэ. Тэрээр жил гаруй хүлээлээ. Энэ бол түүнийг Төв Хорооны шинэ бүрэлдэхүүнд оруулаагүйн нэгэн адил санаандгүй зүйл биш. Өрнөдийн томоохон оронд суугаа элчин сайдын хувьд Будягин Төв Хорооны заасан бодлогыг явуулж ирсэн, гэхдээ өөрийнхөө үзэл бодлыг Төв Хороонд хэлэх эрхтэй байсан юм.

Гэтэл Сталинтай харилцахад хэзээний төвөгтэй. Тэрээр цөллөгт байхдаа оймстойгоо унтдаг зуршлыг нь тоглоомоор дооглосон нэг нөхөртэйгөө дуугарахаа больсон билээ. Сибирьт мань хүн гойд өмгөөлөл хамгаалалтгүй мэт санагдаж даарч бээрдэг байсан тул оймстойгоо унтдаг байжээ. Тэнд байхдаа цоохор торгон хөвөнтэй хөнжлийг эзэгнэдэг байсан. Үүнийг нь бас тоглоом болгоно. Сталин ийнхүү тоглоом хийхийг байдалд зохицож чадахгүй, өөрийнх нь арчаагүй царайг зориуд цохож байгаа мэт хүлээж авна. Түүнийг тоглоом хийхээ больцгоожээ. Түүнтэй муудалцаж болохгүй, яагаад гэвэл буцаад эвлэрч эс чадна. Тод гүрж аялгатай, яхир хатуу үгтэй учир сайхан ярьдаг хүн биш, тэгээд маргалдахын үес бас л хамгаалалтгүй юм шиг байх тул түүнийг гомдоохгүйг бодоцгооно. Гомдоохгүй гэдэг нь түүнтэй зөрөхгүй байна гэсэн үг.

Мартах, санал бодол зөрөх нь цөллөгийнхөн хоорондоо ярьж хөөрөхөд саад болохгүй л дээ. Гэтэл Сталин үзэл санаа өөр хүнийг хувийн дайснаа гэж үздэг тул ганцхан мань хүн л хүнтэй эвлэрэх гэж нэг ч нааштай алхам хийхгүй. Нөхөр нь өөртөө хэрэгтэй ч гэсэн эсгий гутлаа түүнд өгвөл Сталин ингэж л байх ёстой юм шиг авна. Гэхдээ урьд нь маргасан хүнээс бол хэзээ ч авахгүй. Туних, гомдох, яах гэж байгаа нь мэдэгдэхгүй байх нь элбэг болохоор түүнийг тэсвэрлэхийн аргагүй билээ. Бусад нь ан гөрөө, загас жараахайд явдаг байхад ганцхан мань хүн л хаашаа ч явахгүй, оройн цагаар цонхны дэргэд сууж керосин дэнлүүний гэрэлд хичээллэнэ. Сибирийн бөглүү тайгад, тосгоны захын модон байшинд байгаа энэ ганцаардмал, хүнтэй эвлэрдэггүй гүрж хүн нутгийн хүмүүстэй хэл амаа зовж олдог ч гэсэн цаадуул нь түүнийг өрөвддөг байжээ. Бас нөхөд нь ч гэсэн түүнд олон юмыг уучилна.

Түүнтэй ямар нэг байдлаар ойртсон ганц хүн бол Будягин. Мотовилиха нутгийн ажилчин хүү тэрээр Кавказ нутгийн хүнийг анх удаа үзээд хатуу ширүүн нөхцөлийг нь баргийн орос хүн давахгүй хүйтэн цэвдэг Сибирьт цөлөгдсөн дулаан орны энэ хүнийг өрөвдсөн ажээ. Будягин түүнд нэмэр болж, чадах чинээгээрээ тусалж байсан бөгөөд Сталин үүнийг нь тэгэх ёстой юм шиг хүлээж авна. Иван Григорьевич дархны болон төмөр эдлэл засах, сэлбэх ажлыг мэддэг, сүх барьж сурсан болохоор анжис, бууны алиныг ч засчихдаг учир энд байхад түүнд бусдаас амар байлаа. Бас загасчлах дуртай, ялангуяа намрын шөнө завиныхаа хошуун дээр задгай гэрэл асаачихаад загасчлах дуртай. Тэрээр боловсрол сайтай нөхдийнхөө яриа, маргаан, бодол эргэцүүллийг чимээгүй чагнаж, юм их уншихын зэрэгцээ англи хэл хүртэл үзэж байлаа. Олонхи нь герман, франц хэл үзнэ. Ганцхан Сталин л хэл үзэхгүй. Цөллөгийнхөн Будягинд ном өгч тайлбарлаж таниулна. Сталин бас түүнд тайлбарлаж таниулна. Сталин юмны учрыг эрс шулуухан авч үздэг, цээжлэх янзаар ханддаг, өөрийн

мэдлэгийг мэргэн цэцний орой гэж үзэж энэ бүхэндээ бат итгэдэг нь Будягинд бусад нөхдийн ургуулан бодож сайхан ярихаас илүү аятайхан санагддаг байжээ. Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр энэ аятайхан санагддаг нь больж тэрээр өөрөө түргэн хөгжиж боловсрохын хамт Сталинаас илүү боловсролтой, илүү гялалзсан хүмүүстэй замын хүзүү таарлаа. Гэвч цөллөгт хамт байсан энэ найман сард насны нь ажил үйлс болсон хэрэг явдлын амт шимтийг анх амссан болохоор ой тойнд төдийгүй зүрх сэтгэлд хоногшин үлджээ.

Тэрээр иргэний дайны жилүүдэд ч Сталинтай уулзаж учирч явжээ. Чухам тэр үеэс Сталин чухал үүрэг гүйцэтгэж эхэлсэн билээ. Түүний зориг, эрч хүч хувьсгалд хэрэг болж болох байсны хамт хувьсгал эцсийн аргыг хүртэл хэрэглэдэг тул түүний дураараа загнах, хэрцгий авирлах, ганцаараа захирахыг эрмэлзэх чанарыг тэвчиж болохуйц байжээ. Гэтэл бүтээн босголтын үед энэ дутагдлууд аюултай болж хувирав. Сталин ямар ч хяналтгүй, бүхнийг эзэгнэх эрх дархыг олж авчээ. Лениний захианы утга ч үүнд оршиж байсан юм. Сталин үзэл санаанд үнэнч байдлыг өөртөө хэр үнэнч байгаагаар хэмжих болов. Рязановын төгсгөл гэж үзэж байсан зүйлийг Будягин эхлэл гэж таамаглаж байжээ. Тэрээр өөрчлөлтүүд их хурал дээр болно гэж баримжаалж байсан юм. Гэтэл тэр өөрчлөлтүүд гарсангүй. Сталин өөрийнхөө ер бусыг их хурал дээр баталсан, одоо өөрийнхөө хосгүйг баталж эхэлнэ.

Будягин бүх юмыг өөртөө хамааруулж үздэг билээ. Аливаа хувьсгалт үйл ажиллагааг өөрийнхөө үйл ажиллагаа, аливаа алдааг өөрийнхөө алдаа, шударга бус юм болгоныг өөрийнхөө шударга бус үйлдэл гэж тооцно. Нийгмийн донсолгооны их шуурганд өртсөн хүмүүсийн хувь заяаны хариуцлагыг өөрөө хүлээдгээрээ хувьсгалч хүний дээд зэргийн эрэлхэг зоригийг эзэмшсэн хүн. Дэргэд нь буруутай, буруугүй янз бүрийн хүмүүс сүйдэж байхад мань хүн энэ бол шинэ үеийнхэнд зам тавьж байгаа хэрэг гэж итгэж явсан билээ. Жинхэнэ хувьсгал бол ЮУГ сүйтгэж байгаагаараа биш, ХЭНИЙГ бүтээж байгаагаараа аугаа их нь тодрох ёстой.

Сталин Рязановыг эрхлүүлжээ. Иван Григорьевич энэ тухайд эндүүрсэнгүй. Хүнийг Төв Хорооны бүрэлдэхүүнд оруулахдаа түүний зээ дүү баривчлагдсан гэдгийг мэдэхгүй байх ёс байхгүй. Баривчлагдсан дүү нь Рязановын хувьд хоолой дээр тавьсан хутга болж тийм байдлыг үл тоосон нөгөө хүнд тэрээр арга буюу үхэр, нохой мэт үнэнч зүтгэхэд хүрнэ. Хэрэв энэ тийм бол Будягин Сашагийн хэрэгт оролцвоос Сталин тэр хоёрын харилцаа улам ярвигтай болох вий.

Тэглээ ч гэсэн Будягин тэр хэрэгт оролцохгүй байж чадсангүй. Сашад яаж туслах тухай Ленатай нь ярилцан суугаа залуусыг хараад тэрээр сэрдхийн цочиход хүрчээ. Энэ муу санаагүй, цэвэр ариун залуус түүний хувьд бол хувьсгалын үйл хэргийг үргэлжлүүлэгчид. Гэтэл тэр хувьсгалыг бэлтгэж хийлцсэн мань ахмад большевик маань тэдэнд ямар ч хариу өгч чаддаггүй ээ. Сашаг баривчилсны учрыг гадарлаж байгаа болохоор түүнийг баривчилсан нь зүйтэй хэрэг гээд хэлчихэж эс чадна. Гэхдээ энэ бол буруу хэрэг гэж бас хэлж чадахгүй, хэрвээ тэгж хэлэх юм бол яагаад ийм явдал байж болдгийг тайлбарлах хэрэгтэй болно.

Чингээд Будягин энэ хэрэгт оролцоод ямар ч ашиггүй гэдгээ ойлгож байсан хэдий боловч Березинд утасджээ. Түүнийг эрэлхэг зоригтой, шударга чекист гэж мэдэх юмсанж. Тэгээд Саша Панкратов тэгэхгүй хүн гэдгийг биечлэн мэднэ, тийм учраас түүний хэргийн учрыг сайн олж өгөөч гэж Березинд хэлэв.

Березин Панкратовын хэрэгтэй танилцсан тул түүний гэмгүй гэдгийг Будягин, Рязанов хоёрын хэнээс ч илүү мэдэж байв. Тэрээр Сашаг байцаахад нэг удаа байлцаж түүний шударга залуу гэдгийг гадарлажээ. Өтгөн хар хууз сахалтай ч гэсэн нэр төр, зориг, шулуун шударга занг нь тодхон илтгэсэн залуу сайхан царайг нь тэгэхэд олж харж чаджээ. Нөгөө товчхон “Огт яагаа ч үгүй, ямар ч гэмгүй хүнийг!” гэж хэлж байсан нэр төртэй үгс, ямар ч аюулыг үл тоох, амьдралаа тосон хүлээж байгаа идэр насны инээмсэглэл энэ тэр ямархан байлаа! Гэвч Будягин, Рязанов хоёрын хэн нь ч мэдэхгүй олон зүйлийг Березин мэдэхийн гадна тэр хоёрын хэзээ ч таамаглахгүй нэг юмыг мань хүн барагцаалж байгаа билээ.

Урьд Коминтерний удирдагчдын нэг байсан Ломиназе хятадын хувьсгалын тухай Сталиныхаас өөр үзэл бодол хэлж, тэр тухай асуудлыг Шацкин, Сырцов нартай хэлэлцсэн ажээ. Эд нарын тэр ярианаас болж Сталин тэднийг “баруун зүүний эрэмдгүүд” гэж нэрлэж Ломиназег албан тушаалаас нь огцруулж Урал руу хотын намын хорооны нарийн бичгийн даргаар явуулсан билээ.

Түүнд хавгаст хэрэг нээжээ. Тэр хэргийн дотор хуучин Коминтерний ажилтан байсан Черийн Ломиназе шинэ Интернационал байгуулахаар бэлтгэж байсан мэт мэдүүлсэн мэдүүлэг бий. Ямар үндэстэн нь үл мэдэгдэх, тэгсэн мөртлөө өдий төдий улсын харьяат тэр Чер Ломиназетэй холбоотой сүлбээтэй гэх маягаар нэлээд хүнийг нэрлэсний дотор Лениний цагаачилж явахад хэрдээ чухал туслалцаа үзүүлж явсан Польшийн социалист намын зүтгэлтэн агсан Глинскийг нэрлэжээ.

Глинскийн авгай тээврийн дээд сургуулийн захирал. Тэр сургуульд хуучин “ажилчны” эсрэг бүлэгт оролцож явсан, одоо Глинскаягийн орлогч байгаа Криворучкогийн толгойлсон эсрэг нууц бүлэг байсныг илрүүлсэн мэт ярьдаг. Ягода үүнээс шууд шүүрээд авчээ. Глинскийн авгай эсрэг нууц бүлэгтэй холбоотой гэдэг бол Черийн бүдэг бадагхан мэдүүлгийг баттай зүйл болгож байгаа нь тэр. Хөндлөнгийн ямар ч холбоо хэргийг дорвитой, үнэмшилтэй болгодог, ямар нэг нэр, ямар нэг баримт хэргийн материалд байнаа гэж санахад тэгээд түүнийг гол таамаглалтай чадамгай уялдуулж чадвал тэр нэр дорвитой, тэр баримт жинтэй болдог.

Сургууль дотор ямар ч нууц бүлэг байхгүй, Саша Панкратов Криворучкотой ямар ч холбогдолгүй, Криворучко ч Глинскийн хэрэг явдалд огт хамаагүй, Глинский өөрөө Ломиназетэй хэлхээ холбоо байхгүй, Ломиназе ч ямар нэгэн шинэ Интернационал байгуулах гэсэн санаа байхгүй гэдгийг Березин ойлгохын цаагуур ойлгож байв. Гэвч Ломиназегийн хэргийг Ягода өөрөө биечлэн хариуцаж байгаа тэгээд ч энэ хэрэг бүр цаашаа, бүр дээшээ хөвөрнө гэдгийг Березин ойлгож байвч чухам хаа хүртэл хөврөхийг гагцхүү таамаглахаас цаашгүй... Энэ тухай Ягода мэдэж байгаа, энэ хүний үнэ цэнийг Березин сайн мэднэ... Аймшигтай муу ёрын битүү гинж. Хэрвээ Панкратовыг суллах юм бол энэ гинжнээс өчүүхэн ч гэсэн нэгэн гархийг салгаж авсан мэт ойлгогдож болно. Ягода хэзээ ч тэгүүлэхгүй. Бас Вышинский ч тэгүүлэхгүй. Сольц Панкратовыг сургуульд нь буцааж оруулсан, гэтэл Вышинский түүнийг баривчлах зөвшөөрлийг олгосон хүн. Харин Панкратов руу олны анхаарлыг хандуулахгүй сүүдэрт барьзнаж байх хэрэгтэй. Гагцхүү ингэвэл л залууг аварч болно. Одоохондоо бүх юм байгаа чигээрээ л байж байх ёстой, Дьяков өөрийнхөө ажлыг үргэлжлүүлж л байг, түүний үүрэг сургуулийн хэргээр хязгаарлагдаж байгаа, түүнээс илүү

юм тэр мэдэхгүй. Березиний ганц хийсэн юм бол Сашад эргэлт оруулах, шоронгийн номын сангийн номоос ашиглахыг зөвшөөрсөн явдал ажээ. Энэ шийдвэрийг Дьяков хүндэтгэлтэй хүлээж авчээ. Тэрээр Березинийг энд, төв аппаратад удаан ажиллахгүй гэдгийг таамаглаж, ер нь түүний үгийг хүндэтгэн сонсдог байжээ. Эргэлт, ном энэ тэр бол мэдээжээр шаардлагыг сулруулсан хэрэг, гэхдээ мөрдлөгийн эрх ашгийн үүднээс заримдаа хийдэг зүйл, тийм учраас ингэлээ гэж гоочлох юм олохгүй.

–Есоор гүйцэтгэе гэж Дьяков хариулжээ.

Березин хувьсгалын үзэл санааг шүтэж Онцгой комиссын ажлаа хувьсгалт үүргээ гэж үзнэ. Иргэний дайны үед мужийн Онцгой комиссын дарга байхдаа улаантны алан хядах ажлыг хэрэгжүүлж явсан, гэхдээ хувьсгалд аюулгүй гэдгийг нь хараад мэдсэн бол аль нэг урагшгүй либерал буюу айж хулчийсан буржуйг амь хэлтлээд харсан зүгт нь тавиад туучихдаг байжээ. Дьяковын жижигхэн ч гэсэн тас зуурдаг бахимхан гараас хэн ч мултарч яваагүй, түүнд таарна гэдэг бол буруугүй ч байсан буруутай гэсэн үг. Дьяков хүмүүсийн жинхэнэ бурууд итгэдэггүй, буруугийн ерөнхий таамаглалд итгэдэг хүн. Энэхүү ерөнхий таамаглалыг тухайн хүнд чадамгай хэрэглэж, тодорхой таамаглалыг бий болгох хэрэгтэй. Ийм тодорхой таамаглалыг бий болгосныхоо дараа түүндээ өөрийгөө ч захируулна, мөрдлөгийн ажил, мөрдүүлж байгаа хүнээ ч захируулна. Хэрвээ мөрдөгдөж байгаа хүн тэр таамаглалыг нь үгүйсгэвэл тэр нь чухамдаа сайхь этгээд төрд дайсагнаж байгаагийн бас нэг нотолгоо л болно. Дьяковын ойлгож байгаагаар өөрийнх нь энд төлөөлж буй төрд дайсагнасны баталгаа гэсэн үг.

Дьяковын бий болгосон таамаглал (учир явдлын нарийн холбоотой, хэн ч няцаашгүй таамаглал гэдэгт өөрөө үнэн санаанаасаа итгэнэ) дараах байдалтай юм: хуучин эсрэг бүлэгт байж байгаад үнэнд дарагдсан болохоор гомдсон, тэгэхлээр Дьяковын ухаанаар бол үүрд хорсож өшсөн Криворучко дээд сургууль толгойлж байжээ. Тийм хүн зүгээр сууж чадахгүй, ер нь дайсан үүрэглэж суудаггүй, чадах газар болгондоо муу юм хийж байдаг ёстой. Ялангуяа улс төрийн хувьд төлөвшөөгүй залуу хүмүүсийн дунд муу юм хийнэ. Яг тэгтэл хэсэг тийм залуус намын эсрэг ханын сонин гаргасан байна. Энэ хоёр явдлын хооронд холбоо байна уу? Байхгүй байх ёс байхгүй! Тэр хэдэн залуугийн удирдагч оюутан Панкратов Криворучког хамгаалж байна. Энэ санамсаргүй хэрэг үү? Санамсаргүй байж хэрхэвч таарахгүй! Криворучкогийн хэрэг цаг хугацааны хувьд Панкратовын хэрэгтэй санамсаргүй давхцав уу? Үүнийг хэн итгэх юм бэ! Панкратовын ард нь зоригжуулагч байна, хуучин эсрэг бүлгийн этгээд. Криворучко Панкратовыг уруу татсан байна, энэ бол бүр хувьсгалын эсэргүү байгууллага гэсэн үг.

Панкратов няцаж, таамаглал нотлогдоно гэдэгт Дьяков эргэлзэхгүй байлаа. Дьяков мөрдөгдөж байгаа хүмүүсийг мөрдлөгт итгэдэг, тэгснээрээ Зөвлөлт засагт итгэдэг, мөрдлөгт итгэдэггүй тэгэхлээр Зөвлөлт засагт үл итгэдэг хэмээн хоёр ангилна. Түүнээс гадна мань хүн тэднийг протоколын үг үсэг болгоноос өө эрдгийг нь жижгэрдгүүд, өөлж гоочилдоггүй нь жижгэрдэггүйчүүд гэж бас ангилна. Панкратов бол төрийн хуулийн байгууллагад итгэдэг, жижгэрдэггүй, баригдсандаа цочирч балмагдсан, суллагдана гэж горьддог, харилцан итгэлцэхийг хүсдэг, туршлагагүй, гэнэн цагаан сэтгэлтэй, нөхдөө хамгаалж бүх хэргийг, аягүй бол өөртөө илүү ч авахаас буцахгүй хүн. Энэ бол хялбархан тохиолдол.

Криворучког Сашаг барьсан тэр шөнө баривчилжээ. Тэрээр Панкратовын хэрэг гэж сонссон

боловч сургууль нь хэдэн мянган оюутантай болохоор чухам Панкратовыг өөрийг нь санахгүй байна гэж мэдүүлэг өгчээ. Үнэн хэрэгтээ бол Криворучко Панкратов товчоон дээр юу ярьсныг мартаагүй, үнэмлэх бичгээ бүрдүүлэх гэж орж ирж байсныг нь санаж байгаа билээ. Тэрээр Панкратовыг танихгүй гэж зүтгэсэн нь өөртөө хор хүргэчих байх гэсэндээ тэгсэн хэрэг биш юм. Энэ үйлдэл бол урьд өмнө хэзээ нэгэн цагт ямар нэгэн эсрэг бүлэгт оролцож явсан хүмүүсийн эсрэг чиглэсэн арга хэмжээ учраас Криворучкод нэмэр болох ч юм байхгүй, нэрмээс болох ч юм байхгүй. Бас нөгөө таамаглалыг тайлж мэдсэндээ ч тэгсэн хэрэг биш, мань хүн Панкратовын баригдсан гэдгийг ч мэдээгүй. Харин түүний нэрлэсэн нэр болгон тэр нэрийн эзэнд хор хүргэхээс өөр юм байхгүй гэдгийг мэдэж байсан учраас тийнхүү танихгүй гэж зүтгэж байжээ.

Сашад дөрвөн ном авчирч өгсний дотор түүний захиалсан номын нэг нь ч байгаагүй боловч номын сангийн хүн эрхбиш ойролцоо юм явуулжээ. “Арилсан мөрөөслийн” оронд “Цезарь Бирото”, “Дайн ба энчийн” оронд “Бага нас”, “Өсөх нас”, “Идэр нас” гурав, “Природа и люди” сэтгүүлийн 1905 оны дугаар, Красная новь” сэтгүүлийн 1925 оны хоёр дахь дугаарыг өгсөн байв. Бүгд ноорж навсайтал нь уншиж эдэлсний гадна “Хотын Бутырын шоронгийн номын сан” гэсэн цэнхэр зууван тамгатай аж. Бальзакийн зохиол 1899 оны хэвлэл, Толстойнх 1913 оных. Олон хуудас дутуу байх бөгөөд номын эцэст буй байхгүй хуудасных нь жагсаалтад тэр болгон бүртгэгдээгүй байв. Тэглээ ч гэсэн бүтэн долоо хоногийн баяр болно. Саша эхлээд сэтгүүлүүдийг гүйлгэн харснаа номнуудаа уншаад дараа нь сэтгүүлүүдээ дахин уншив. “Красная новь” сэтгүүлээс Есениний “Хөхөмдөг манан. Цаст уудам хөндий...” гэдэг шүлгийг олж үзэв. Энэ шүлгийг Саша урьд нь олж үзээгүй билээ. Тэрээр “Цезарь Биротог” хуучин уншсан агаад тэгэхэд энэ урагш муутай үнэртэн бэлтгэгчийн явдал уянгын гуниглал шиг санагдаж байсан бол энэ удаа сэтгэл хөдөлгөжээ... “Зовлон гэдэг суу билэгтэнд бол ахин дээшлэх шат, христосын шашинтанд ариун усны угаалга, адтай хүнд нууж булсан алт, арчаагүй доройд хөлгүй харанхуй” гэж бичжээ. Тэрээр суу билэгтэн ч биш, сүсэгтэн ч биш, адтай сэргэлэн ч биш, арчаагүй дорой ч биш. Гэхдээ л энэ үгэнд өөрийнх нь хувьд ямар нэгэн чухал зүйл байх шиг санагдав.

Тэрээр долоо хоног номоо уншиж, гэрээс ирсэн цэвэрхэн цагаан хувцсанд ороогдон, амттан идэж хэрдээ жаргалаа. Хөшиглөсөн махаа шөл рүүгээ хийж бүлээсгээд агшаасан будаан дээрээ нэмэхэд үдийн хоол нь хүн идэж болохын дайтай болно. Өглөө, оройд нь загасан талх, цөцгийн тос, хиам, бяслаг энэ тэрээрээ талхны зууш хийж идэхэд сургуулийн өглөөний хоолны үнэр гарч шоронгийн үнэр дарагдана. Гэдэс цадаж, бие нь тавирахуйд орондоо орж номоо уншина. Өдрийн цагт хэвтэхийг хориглодог боловч Саша хонгилын харуулуудын үгийг огт тоосонгүй, цаадуул нь ч түүнийг зоргонд нь орхиж, гагцхүү дарга нарын бараанаар ширүүлж босгоно. Ном уншиж, хиам, шоколад идэж нэгэн муу зан сурам өег долоо хоногийг барлаа. Тэрээр шоронгийн амьдралд дасаж аргыг нь олж байх шиг санагдана... “Энэ насандаа мэрийсэн ч, эс мэрийсэн ч бүгд энх амгаланг олж, цөм тэнд очицгооноо...” Олны энэ үгэнд үнэмшил төрөхгүй ч гэсэн сэтгэл тайтгарна.

Ном сэтгүүлд бичигдсэн амьдралыг түүний одоогийн амьдралтай адилтгах юм даанч алга, урьдах амьдралтай нь ч гэсэн дээ. “Бага нас”, “Өсөх насанд” бичигдсэн зовлон зүдгүүр түүний бага залуугийнхаас шал өөр аж.

Мань хүн тэр үед эцэгтээ,

–Би ээжийгээ доромжлуулахгүй шүү гэж хэлсэн.

Эцэг нь бор нүдээ бүлтийлгэн харснаа хоёр гараараа толгойгоо барьж,

–Сайн хүү... гэж хэлээд уйлчихсан.

Эцэг бол эцэг. Хэдийгээр хүйтэн гартай ч гэсэн тэр гарын илбэ хар багаас нь сэтгэлд хоногшсон билээ. Эцгийгээ аргадаж өршөөл гуймаар санагдсан. Эцэг нь нүүрнээсээ хоёр

гараа салгахад нүд нь хорсолтой бөгөөд хув хуурай байсан.

–Бидний хэрэгт оролцох эрх хэн чамд олгосон юм бэ?

–Энэ чинь миний ээж.

Эцэг нь хэдэн өдөр үг дуугүй босож, сахлаа хусаж, нүүр гараа яаралгүй угааж, хувцсаа өмсөөд, өөрийгөө тольдон сайн харж авснаа үг дуугүй ширээ рүү сууж мөн л дуу шуугүй идэж уучихаад бичиг цаасаа хумьж авч цүнхэндээ хийж нэг юм амандаа гүвтнэснээ баяртай ч гэж хэлэлгүй ажил руугаа гараад явчихдаг болжээ. Буцаж ирэхдээ гэр орноо ууртай харцаар эргүүлдэн ширвэж, хоол ундаа ганц үгийн зөрөөгүй идэж тавгаа торхийтэл түлхэнэ. Эхийнх нь хулчгархан асуултад хариу өгөхгүй. Харин үдэш орой болсон хойно ээж аав хоёр нь өөрсдийнхөө өрөө рүү орж тэндээс эцгийнх нь битүүхэн дуу сонсогддог боловч ээж нь ер чимээ гарахгүй байгаад л байна. Ингэж чимээгүй байснаасаа болоод үнхэлцэг нь хагарчих вий гэж Саша айж санаа нь зовно.

Дараа нь эцэг нь Сашад,

–Чамтай ярих хэрэгтэй байна гэж хэлжээ.

Тэр хоёр гэрээсээ гарч Арбатаар алхав. Гудамжны чийдэнгийн гэрэлд цасан ширхэг бүүрлэн бужигнана. Эцэг нь донхор малгайтай, түүнтэй ижил үстэй захтай пальтотой, сахал самбайгаа мөлчийтөл хуссан, гоолиг сайхан эр бөгөөд өөртэй нь зөрөхийг тэвчиж чаддаггүй, түс тас тийм нэгэн бээр Сашатай зэрэгцэн явна.

...Тэрээр өөрсдийнхөө харилцаанд хүүгээ хөндлөнгөөс оруулах дургүй байжээ. Эх нь л хүүхдийг хар багаас нь эцэгт нь муу болгосон. Тэдний эв түнжингүй байгаагийн буруутан нь тэр эх. Тэр л түүний тэмүүлэл, сонирхлыг ойлгодоггүй байсан, тэрээр эгч дүү нартайгаа л илүү дотно байсан. Хардах сэтгэлийн чадах юм ердөө л энэ.

Саша яах учраа олохын аргагүй гунигт автав. Тэрээр энэ гадаа гудамжинд эцэгтэйгээ юу гэж зөрөхсөн билээ, эцгийн чих хатууг хэлэх үү, ярина гэж хашгирна гэсэн үг. Тийм учраас Саша зөвхөн,

–Хүмүүс цуг амьдарч чадахгүй бол салах ёстой гэж л хэлжээ.

Эцэг нь сарын дараа Ефремовын хиймэл каучукны үйлдвэр рүү яваад өгсөн билээ. Тийнхүү Саша арван зургаан насандаа өрх гэр толгойлох ажлыг өөртөө авахаас өөр аргагүй болжээ.

Дьяков Сашаг дуудахгүй л байв. Ингэлээ гэж түүний сэтгэл зовсонгүй. Тэрээр анхны байцаалтыг горьдлого тавин хүлээж байсан, хоёр дахийг нь айж хүлээж байсан бол одоо горьдох, айхын аль нь ч үгүй болжээ. Гагцхүү Криворучкогийн тухай бодол л амар заяа үзүүлэхгүй байв. Криворучког баривчилж мэднэ, тэгээд Сашад тогоочийн тухай нөгөө нэг үгийг хэлснээ хүлээчихнэ. Тэгэх юм бол Сашагийн худлаа хэлсэн нь баригдаж нэгэнт худлаа хэлдэг нь мэдэгдсэн хойно Маркийн холбоотой гол асуудлаар түүнд итгэнэ гэж байхгүй болно.

Криворучко үүнийг яах гэж хэлнэ вэ дээ? Ийм бүтэлгүй байдалд өөрийг нь оруулчихсан байх юм. Чалчаа нөхөр! Криворучкогийн асуудлыг намын байгууллагын товчоон дээр хэлэлцсэн бол Саша яах байсан бол? Тэнд бол тэр үгийг нуухгүй л байхсан... Нөхөр Криворучко юу хэлэх гээд юу хэлснийгээ тайлбарлаг! Яахлаар энд Саша өөрөөр хандах ёстой билээ? Яагаад Криворучког хаацайлах ёстой вэ?

Бүх юмыг байсан чигээр нь ярьж өгөөд өөрийгөө энэ хүнд дарамтаас суллана. Өөрийнх нь сэтгэл л сэвгүй болж байвал бусад нь ямар хамаа байна... “Сибирь мөн аймаар шүү. Сибирь хол шүү, гэвч хүмүүс Сибирыг ч гэсэн аж төрж байгаа...” Хаана ингэж хэлсэн байдаг билээ?

Ингээд Саша шоронд аж төрж, хэвтэнэ, уншина, хиам, шоколадыг амтархан иднэ, шөнө болгон халуун усны шүршүүр дор дуу дуулна, бодно, дурсана. Битүү сахал ургачихсан, тэрээр хэзээний сахлаа илдэг болчихсон байв. Сахалтай ямар байгаа бол хэмээн өөрийгөө хармаар санагдавч толь байх биш.

Цаас харандаатай хянагч дахин хүрч ирж номуудыг нь авав. Саша шинэ захиалга бичлээ. Тэрээр аль нэг нь номын тавиур дээр хэвтэж байж магадгүй хэмээн энэ удаа арван ном захиалав. “Дайн ба энх”, “Арилсан мөрөөсөл” хоёрыг давтан бичиж, нэг, хоёр, гуравдугаар сарын зузаан сэтгүүлүүд, Стендаль, Бабель, баригдахынхаа өмнө уншиж эхэлсэн Гиббоны “Ромын эзэнт улсын задран унасан түүх” энэ тэрийг захиалж, бас унших дуртайгаас Гоголийг, дургүй ч гэсэн гэтлэх хэрэгтэй хэмээн Достоевскийг нэмж бичлээ. Мөн нөгөө хуулиа дахиад захиалав. Юу шаардаж байгааг нь мэдэг л дээ. Түүний захиалгыг Дьяков хянаж үздэг нь зайлшгүй. Тийм учраас Саша өөрийнхөө эрхийг мэдэх хүсэлтэй байгааг Дьяков мэдэж байг.

Хоёр өдөр номгүй байснаар хуучин байдалдаа эргэж оров. Дахиад л битүү дүлий хана, арга барагдам анир чимээгүй байдал, мөшгиж мөрдсөн шагайвч, жорлон руу явах аян, ээжийнх нь ирүүлсэн идэх юм дууссан болохоор дахиад л идэж боломгүй хоол, ходоодны шар хөөрөлт... Тэрээр Катягийн тухай бодож халуун гар, омголтсон уруулыг нь дурсан санана. Унтаж чадахгүй дэмий л босож холхино. Гэтэл хянагчид өрөөн дундуур шөнө холхихыг хориглоно.

–Хоригдол оо, хэвтээрэй!

Тэгээд хэвтээд өгнө, гэхдээ унтаж чадахгүй. Хэрвээ нойрсож эхэлбэл зовлонтой зүүд зүүдэлж дээр үед арван долоотой байхдаа яасан шиг хачин юм харагдана...

Тэрээр арван долоотой байхдаа ээжтэйгээ нэг удаа Липецк явжээ. Тэр хоёрын сууж байсан айлын эзэгтэй дээр бэр нь Самараас иржээ. Тэр хүүхний нөхөр нь Самарт төмөр замд алба хаадаг юм байж. Елизавета Петровна гэдэг нүцгэн биен дээрээ дөнгөж зөрүүлсэн багадсан халаадтай, хонгор үстэй туранхай бүсгүй. Самарын бэртэгчин тэр бяцхан бүсгүй Саша руу онийж жишисхийн харж жогтой инээмсэглэн маяглана. Тэгтэл энэ жогтой инээмсэглэл, дутуу товчилсон халаадын цаанаас харагдаад байгаа бие, хямдхан үнэртэй ус энэ тэр Сашагийн сэтгэлийг догдлуулж дөнгөжээ. Бүсгүй өдрийн цагаар халаадаа ярж шулуухан цагаан хөлөө наранд ээгээд цэцэрлэг дотор хэвтчихнэ. Саша түүний байгаа зүг рүү харахгүй хэрнээ алимын модны доороос цагаан дэр, эрээн халаад, булбарай өвдөгтэй тэгшхэн нүцгэн шилбэ цухуйж байгааг мэдэхийн сацуу өөр дээр нь туссан бүсгүйн жишүү харц, инээмсэглэл хоёрыг бас мэдэрнэ.

–Са-шша... гэж бүсгүй нэг удаа “ш” үсгийг сунжруулан өгүүлжээ.

Мань хүн дэргэд нь очиж суулаа.

–Саш-ш-ша хэмээн бүсгүй түүн рүү эргэхэд халаадын нь энгэр задгайрч туранхай мөр, бяцхан хөх нь нүцгэрч тэрээр,

–Саша... Та өдөржингөө хаагуур зугаацдаг юм бэ? Охидуудтай юу? Надад ярьж өгөөч... гэв.

Саша бүлх залгисан мэт ганц ч үг дуугарч чадахгүй дэмий л тас хавчсан хоёр хөл, бяцхан цагаан хөхийг нь харна... Нар шаран төөнөж хэдгэнэ дүнгэнэн алим ханхална. Мань эр босох битгий хэл, хөдөлж ч чаддаггүй болов. Энэ байдлыг нь бүсгүй нүдээрээ ч харж, ухаанаараа ч ойлгож, нөгөө л жогтой инээмсэглэдгээрээ инээмсэглэн дотроо дооглон байх шиг санагдахад бүр иччихэв.

–Ном л уншаад байх юм, тэгж байгаад дон тусчихав даа.

Бүсгүй барьж байсан Франсын ботийг нь аваад,

–Өгөхгүй шүү! гээд ардаа нуучихлаа.

Саша номоо авах гээд гараа сарвайтал тэр хоёрын гар зөрөлдөн ороолдож бүсгүйн биеэс халуу цоргиод явчихлаа. Хүүхэн хашааны хаалга руу хулмаганан хялайснаа толгойгоо гэдийн уухилан амьсгаадаж царай нь нэг л үл ойлгогдом, шийдчихсэн янзтай болов. Тэгснээ хүүг хүзүүдэн авч өөр лүүгээ татваас тэр хоёрын уруул шүргэлцэж хүүхэн ч ууцаараа хэвтээд өгөх нь тэр.

Бүсгүй дараа нь хүүгийн нүд рүү шагайж инээд алдан байв.

–Юу болгочихсоноо хараач... Одоо угаахаас өөр үггүй болчихож. Чамд эвгүй байна уу, тийм үү?.. Зүгээр, хонгор минь, анхны удаа л эвгүй байдаг юм, чи анх удаа л ингэж байгаа биз дээ, тийм үү, хэл л дээ?

Сашад ичгэвтэр байсан тул мань хүн хүүхнээс дөлж эхэлсэн боловч маргааш нь үдийн хоол идэж байхдаа цаадах нь,

–Саша, чи эр хүн байна даа, намайг завиар зугаацуулж өгөөч гэжээ.

Гэтэл хүүгээ Липецкт уйдаж байна гэж санаа зовж байсан ээж нь,

–Саша, тэг тэг гэв.

Липецкийн тэндэх голыг Воронеж гэдэг аж. Тэр хоёр завиар Воронежийн нөгөө эрэгт хүрч зүлгэн дээр гарахуйд хүүхэн тооцоолсон ёсоороо өөрийгөө жишим ч үгүй түүнд тушаалаа.

Хүүхэн тэр шөнөө түүн дээр хүрээд ирэв. Саша хоолны өрөөний буйдан дээр унтдаг байжээ. Тэгээд шөнө болгон ирэх болж, өдөр нь бас Воронежийн нөгөө эрэг рүү аваад явчихдаг

болов.

–Шулам чинь нялх хүүхэдтэй орооцолдчихлоо, ээ банзал чамайг гэж хадам эх нь зүхнэ.

Сашагийн ээж юу ч эс анзаарна.

Елизавета Петровнагийн нөхөр ирээд ээжээсээ ямар нэг юм дуулсан бололтой Саша руу сэжигтэй харах болжээ. Елизавета Петровна нөхөртөө халамжит ханийн царай гарган маяглахын хамт Сашаг ухаангүй дурласан банди гэж цаашлуулна. Нөхрийнхөө дэргэд инээд алдан үгээ сунжруулж,

–Өө, миний хонгор хүрээд ирлээ... гэнэ.

Хүүхний ингэж аальгүйтэх, өрөөндөө орчихоод нөхөртэйгөө шивгэнэлдэн инээд алдацгаах энэ тэр нь Сашагийн дургүйг хүргэнэ. Гэвч мань хүн төдөлгүй үйлдвэрт орох ёстой байсан учир ээжийгээ Липецкт орхичихоод Москва руугаа яваад өгчээ. Үүнээс хойш хүүхнүүдээс зөндөө удаан дайжжээ.

Нэг удаа үйлдвэр дээрээ субботник хийж хашаа цэвэрлэж, түлээ буулгаж, цас арилгажээ. Гуравдугаар цехийн аппаратчин Поля гэдэг өндөр гоё хүүхэн түүнтэй зэргэлдээ ажиллаж тоглоом хийн цаашлуулж байснаа субботник дуусахад,

–Манайд очиж дулаацъя гэж аяархан хэлэв. Тэгснээ,

–Би өнөөдөр ганцаараа байгаа гэж нэмж шивэгнэжээ.

Тэр хүүхэн дэндүү илэрхий хэлсэн тул мань эр тэгэхэд тэднийд очоогүй. Тийнхүү очоогүйдээ одоо харамсана.

Хуял тачаал амар заяа үзүүлэхгүй оволзон бүхийд орь ганцаар байх нь зарим үед юунд хүргэдгийг тэрээр мэдэх тул тэгэх вий хэмээн эмээдэг байлаа. Өглөө, орой дасгал хийж, өдөр нь хэвтэхээ больж, өөрийнхөө хоёр булангийн хооронд өдөрт арван мянга алхах норм тогтоож тэр ёсоор холхин, шүршүүрт орохдоо цэв хүйтэн усаар шүршиж, аль болохоор орой унтаж, боломжоороо эрт босно.

Хоёр хоногийн дараа ном авчирч өгсөн тул тэрээр дахиад уншлагадаа автлаа. Харин хэвтэж уншихаа больж, суугаа эсвэл хана налаад босоогоороо уншдаг болжээ. Энэ удаа Гиббоны эхний хоёр боть, “Карамазовын хөвүүд” энэ тэрээс гадна “Амьгүй албатын” оронд “Тарас Бульбаг” ирүүлсэн байв.

Тэрээр хөршгэй болж үзлээ. Хавар намрын сэмэрсэн пальто, уранхай шаахай, саравчтай малгайтай хатангир туранхай залуу. Түүнийг өрөөндөө оруулчихаад дараа нь ор, гудас, хөнжил гурвыг нь авчирч өгчээ.

Нэр Савелий Кусков гэдэг, Бутырын шоронд даруй таван сар сууж буй Москвагийн багшийн дээд сургуулийн гуравдугаар курсийн оюутан ажээ. Түүнийг Сашатай хоёр хонуулаад аваад явчихсан, харин орыг нь үлдээжээ.

Тэрээр бүрмөсөн солиорчихоогүй юм гэхэд ямар ч байсан хийтэй болчихсон хүн шиг Сашад санагджээ. Орон дээрээ хэдэн цагаар үг дуугүй, хөдөлгөөнгүй хэвтэж байснаа гэнэтхэн ухасхийж босоод ор мөргөн нааш цааш холхиж “Хонгор зул, хонгор зул, хээр талаар алаглан байна” хэмээн аяархан гунганана. Ийнхүү Апухтины шүлгийг нэгэн хэмээр гүвтнэх нь солиотой байх гэсэн бодлыг улам лавшруулна.

Тэрээр салхинд ч гараагүй, Сашатай явж усанд ч ороогүй, биеийн тамирын дасгал ч хийгээгүй. Москвад хамаатан садан, ойр дотнын хүн байхгүй учир эргэлт ирэхгүй, гэхдээ шоронгийн зөөгчдийн авчирсан хоолыг тэр даруйд нь идэхийн оронд тэртэй тэргүй зөөгтсөн юмыг бүр хөрсөн хойно нь гоочлоод тавгаа хайш яйш зайлахдаа өөрийнхийгөө мөлчийтөл угааж байгаа Сашаг тоомсоргүйхэн харна. Саша түүнийг байхад ээжээсээ хоёр дахь эргэлтээ аваад, ирсэн бүх юмыг ширээн дээр гаргаж дайлсан боловч Савелий бараг юунд ч гар хүрээгүй. Гиббоны ботийг жаахан барьж үзэж байгаад тавьчихсан. Харин Гоголь, Достоевский хоёрын тухайд бол хуучин уншсан гэж хэлсэн. Сашагийн хэргийн тухай ер сонирхоогүй, харин өөрийнхөө хэргийн тухай сэтгэлийн хөдөлгөөнгүй ярьж өгсөн. Тэрээр Себежийн районх бөгөөд тэдний тосгон хил дээр байдаг аж. Өвлийнхөө амралтаар гэртээ харих санаатай байтал ээж нь захиандаа тэдний нутагт задгай мөнгө ховорхон учраас юм авах, зарах, хариултаа авах гэж үйлээ эдэлж байгаа тухай бичсэн гэнэ. Тэгээд мань хүн мөнгөн зоос хураадаг болжээ. Гэтэл нэгжлэгээр түүнээс хорин найман рубль дөчин копейк олдсон учир түүнийг гадаадад зугтах санаатай байсан гэж хэрэг тулгажээ. Гадаад хэлний факультетэд суралцдаг байсныг бас хэлэх үү. Тулгасан хэргийг хүлээсэн, мөрдлөг дуусчихсан, одоо ял заагдахаа хүлээж байгаа ажээ.

–Яах гэж хүлээсэн юм бэ?

–Үгүй гэж яаж нотлох вэ дээ хэмээн Савелий номой хариулав.

–Чи нотлох ёстой биш, цаадуул чинь нотлох ёстой.

–Харин тэгээд л цагаан мөнгө хураасан гээд нотлоод байгаа юм.

Гайхалтай хачин шүү. Гэвч мань хүнийг өөрийг нь нэг ханын сониноос болоод юм уу, эсвэл нагац ахаас нь болоод баривчилсан гэж хүнд ярих юм бол бас хэн ч үнэмшихгүй билээ.

Савелий оргох тухай шоронгийн домог ярихаараа л жаахан сэргэнэ. Цонхны төмөр торыг тас хөрөөдөж дээвэр дээр авирч гараад тэндээс бас нэг дээвэр лүү гарч дараа нь хашаан дээр харайж буугаад тэндээсээ гудамж руу үсэрч зугтана. Тун саяхан валютын хэрэгтэй хоёр хүн дөрвөн давхраас шууд гудамж руу харайж буугаад оргосон гэхчлэн ярина.

Саша шоронд хэдий удаагүй ч гэсэн оргох арга байхгүй гэдгийг ойлгож байгаа билээ. Гэхдээ түүнтэй маргасангүй. Гагцхүү Савелийн томоогүйг л гайхна. Сургуульд байхын мэдэх хэдэн үгээ мартаагүй тул түүнтэй германаар ярих гэж үзэв. Савелий германаар түгдрэхгүй сайн ярьж байсан тул мань хүн түүнийг аягүй бол багшийн дээд сургуулийн оюутан огт биш байх гэж сэжиглэж байсан нь арилав.

Савелий шоронгийн эмнэлгийн тухай ярихдаа бас яггүй сэргэнэ. Янз бүрийн кабинет,

цахилгаан эмчилгээ, шүдний эмч энэ тэр гээд бух юм тэнд бий. Гадагшаа, дотогшоо толгойтой хатиг гарах энэ тэрд дор нь хөх гэрэл рүү аваачна, тэгээд өдөр болгон шарна, тусгай өрөөнд ч оруулж магадгүй тэгэх юм бол тэнд цагаан талх, сүү өгнө. Өөрөө юу ч идэхгүй хэрнээ цагаан талх, сүүний тухай баяр хөөр болж ярих нь ойлгохын аргагүй.

Тэрээр Сашад хэрэгтэй зарим нэг чухал зүйлийг бас ярьжээ. Хэрэв өрөөнд эмч ирээд “Юу өвддөг вэ?” гэвэл цөллөгт явах болсон гэсэн үг. Тийм учраас өмнө зүг юм уу, Дундад Ази руу эсвэл Казахстанд явъя гэвэл уушигны сүрьеэ, хэрэх эсвэл радикулиттэй гэж хэлэх хэрэгтэй. Умард нутаг руу явъя гэвэл зүрх муу гэж хэлнэ. Харин эмч ирэхгүй бол хорих газар гэсэн үг, тэгэхлээр оноосон газар нь л очихоос өөр үггүй.

Тэд нарын байгаа корпус, бас бусад корпус ямар ямар нэртэй, ямаршуухан байдалтай байрласан байдгийг Саша мөн түүнээс мэдэж авав. Хашаан доторх цамхгийг Пугачёвын гэдэг гэнэ. Нөгөө салхинд гардаг талбай хамгийн давчуухан нь юмсанж. Түүнээс тавиу талбайнууд байдаг, хамгийн аятайхан нь эрүүгийн хэрэгтнүүдийн ажил хийдэг байрны тэндэх бөгөөд тэд нараар гадагш нь зурвас илгээж болдог гэнэ.

Гурав дахь өдөр нь Савелийг аваад явчихав. Тэрээр яг ирсэн шигээ л аан уунгүй яваад өгчээ. Танихгүй хүн дээр ирээд танихгүй хүнээс явах нь энэ.

Гэвч Саша Савелийг үүдэнд очиход нарийхан бөгтөр, эрхшээлд автсан нурууг нь хараад бас үг дуу ч үгүй, эргэж ч харалгүй өрөөнөөс гарахыг үзээд шоронгийн хязгааргүй зам гэгчийг ухаарав. Энэ зам дээр мань эр олон хүнтэй тааралдах вий. Савелий анхных байжээ.

–Нөхөр Будягин, тантай одоо ярих гэж байна.

Дараа нь сайн танил дуу,

–Сайн байна уу, Иван! гэх нь сонсдов.

Иван Григорьевич Сталиныг овгоор нь нэрлэж заншаагүйн дээр нэрээр нь нэрлэж зүрхэлсэнгүй. Тийм учраас зүгээр л,

–Та сайн байна уу... гэж хариу мэндлэв.

–Хүрч ирчихээд орохгүй байх шив, их зантай болж, замаа мартжээ дээ.

–Би бэлээн. Хэзээ очих вэ?

–Бэлэн юм бол хүрээд ир. Зэрэгцээ аж төрдөг шүү дээ.

Будягин Сталиныд сүүлийн удаа хоёр жилийн өмнө Надяг нас барахаас сарын урьдхан очсон билээ. Дараа нь Зөвлөлтөд ирэхдээ бүх ажил явдлаа Сталины итгэлийг хүлээсэн Гадаад хэргийн ардын комиссар Литвиновтой ярилцаж шийддэг байжээ.

Сталин Зөвлөлт Холбоот Улсын эсрэг хүч бол Англи, Франц, Япон гурав гэдэг номлолтой. Англи бол ЗСБНХУ-ыг өөрийнхөө колонийн эзэмшилд заналхийлж байна гэж үздэг. Япон бол Хятадад эзэрхийлэхэд нь, Франц бол Европт нөлөөлөхөд нь саад болж байна гэж үздэг. Үүний хамт Англи, Япон хоёр бол дэлхийн зах зээл дээр Америкийн Нэгдсэн Улсын гол өрсөлдөгчид. Ялагдсан Герман ялсан Францын эсрэг сөрөөд зогсож байна.

Ингэхлээр хамаг нарийн төвөгтэй асуудлууд ерөөсөө хялбархан болно. Нэг талаас Англи, Франц, Япон, нөгөө талаас ЗСБНХУ, АНУ, Герман. Нарийн төвөгтэй юмыг хялбархан болгож авч үзэхийг Сталин өөрийнхөө аугаа их авьяас гэж үздэг билээ.

Аль Веймарын Бүгд Найрамдах Улсын үед бүрэлдэн тогтсон Сталины тэр номлолыг Иван Григорьевич хуучирсан зүйл гэж үздэгийн гадна түүний юм болгоныг хялбарчилдаг чадварыг сүйрэл гэж тооцдог байлаа. Гитлер засгийн эрхэнд гарсан явдал хүчний харьцааг өөрчилж германы асуудлыг үндсэн асуудал болгож байгаа юм.

Литвинов Будягины энэ үзэл бодлыг хараажаар хуваалцаж байвч үүнийгээ ил хэлэхгүй байв. Тэрээр цаг хугацаа Сталины байр суурийг өөрчилнө гэж найджээ. Тэгээд Будягинд “Laisser pesserx”[6] гэж хэлсэн юм.

Сталин Европыг эс мэдэх тул өрнөдийн ажилчдын гоёлын хувцастай удирдагч нартай усны дусал шиг адилхан, бүхнийг мэдэмхийрэн бардамнадаг намын цагаачин сэхээтнүүдийг жигшин үздэг билээ. Өөрөө бол Орост нууц байдалд аж төрж цөллөгдөхдөө цөллөгдөж, оргохдоо оргож, нуугдахдаа нуугдаж явсан. Гэтэл тэд бол хилийн чанадад аюулгүй байдалд

юм бичсэн шиг, ном уншсан шиг аж төрж нэрд гарцгааж байсан. Тэрээр Лондонд Намын Тавдугаар их хурал дээр тэднийг яг дэргэдээс нь сайн харж авсан.

Сталин үүнээс өмнө гадаадад зөвхөн Таммерфорс, Стокгольм хоёрт байж үзжээ. Гэхдээ энэ хоёрт болсон их хурлыг большевик, меньшевик, бундынхан, польшийн болон латвийн социал-демократууд нийлээд гурван зуу гаруй төлөөлөгч цугларсан Лондонгийн их хуралтай жишихийн арга байхгүй. Сталин дэлхийн их гүрний нийслэл, хөрөнгөтний ардчиллын бат цайз, капиталист Вавилон болсон огт мэдэхгүй тэр хотыг анх удаа төдийгүй амьдралдаа цорын ганц удаа үзсэн нь энэ. Ойлгомжгүй харийн уламжлал дунд өсөж бойжсон амгалан тайван улсын дотор хэл мэдэхгүй мань хүн үнэхээр гомдмоор тоогдохгүй амьтан байжээ. Ядахад хүзүүнийхээ ороолтыг гээчихсэнийг хэлэх үү, тэр жилийн дөрөвдүгээр сар Лондонд хүйтэн байсан учир Литвиновтой цуг шинэ ороолт авах гэж яваад таарах юм олж авч чадаагүй тул ширүүн ноос хүзүү рүү хатгаад байжээ. Хамгийн зөөлөн, үнэтэй ороолт худалдаж авсан боловч Сталин янгуучилж шилээ шөргөөн англичуудыг зүхэж байжээ. Усан онгоцны засварын газрын хавьд Литвинов нэг тийшээ түр хөндийрөөд ирсэн чинь Сталин руу засварчид хэдийн шавчихсан байжээ. Цаадуул нь ямар нэг юм асуухад мань хүн хэл мэдэхгүй болохоор хариу хэлсэнгүй. Литвинов яг Лондонгийн хүн шиг англиар ярьдаг зоригтой хүн болохоор засварчдыг хөөж тараажээ.

Литвинов хожим нь нөгөө хүзүүний ороолтны тухай Будягинд яриад харин засварчдын тухай бол хэзээ ч, хэнд ч ярьсангүй. Тийм юм ярьсан байвал Сталин өршөөхгүй л дээ. Багаасаа сул дорой байсан учир биеийн хүч тэнхээ, эр зоригт нь эргэлзсэн аливаа юманд жигтэйхэн өөнтөгч. Энэ зан нь сүүлдээ хардах, сэжиглэх зан болж хувирчээ.

Тэрээр бүр цөллөгт байхдаа хэрцгий авирлахын хариуд түүнээс нь бүр хэрцгий догшин авирлах хэрэгтэй, ингэвээс хүмүүс үүнийг хүчтэйд тооцдог юм гэж Будягинд ярьдаг байсан билээ.

Өвлийн нэгэн урт үдэш Сталин өөрөө усан онгоцны засварчдын явдлын тухай Будягинд ярьж өгчээ. Гэхдээ мань хүнийг цаадуул нь энэтхэг хүн гэж санаад зодох гэсэн боловч өөрсдөө намалдгаа нээлгээд зугтацгаасан гэх маягтай ярьжээ. Тэрээр “намалдгийг нь нээх” гэдэг үгэнд онцгой дуртай билээ.

—Тэр магтуулсан английн ажилчин анги чинь яг эзэд шигээ л колоничлогчид байгаа юм гэж Сталин хэлжээ.

Будягин Сталинд өөрийнхөө үзэл бодлыг мэдээлэх ёстой гэж үзэж байсан тул түүнтэй уулзах гэж жил гаруй оролдсон юм. Сталины итгэсэн юмыг өөрчлөх хэцүү гэдгийг тэрээр мэднэ. Энэ хүн бол хүнтэй сайн байснаа муудахдаа амархан болохоос биш муу хүндээ сайдна гэж хэзээ ч байхгүй. Гэвч Сталин дайнаас болгоомжилж байгаа гэдгийг Будягин бас мэдэж байжээ,

Түүний оролдлого ямар ч үр дүнгүй болно гэдгийг Будягин одоо ойлгож байв. Цаг хугацаа Сталины байр суурийг өөрчилсөнгүй, харин өөрийг нь өөрчилжээ. Мань хүн өөрийнхөө алдаа мадаг хийхгүй гэдэгт одоо хэзээ хэзээнээс илүү бат итгэжээ. Хэрэв түүнтэй зөрөх юм бол юм юугаар дуусахыг Иван Григорьевич тов тодорхой ухамсарлаж байв.

Будягин Кремль рүү хуучин шигээ Воздвиженкаар биш Герцений гудамжаар явав. Манежийн тэндэх талбайг хөндлөн гарч Александрын цэцэрлэгийн хашааг дагаж явсаар Троицкийн хаалга хүрч тийнхүү замаа хэдэн минутаар сунгажээ. Тэрээр ярих юмаа сайтар нягтлан бодох гэж ингэсэн боловч хувь заяанд нь гайтай уулзалт болж магадгүй юм шиг совин татаад байгаа энэ уулзалтыг хойш татах гэсэндээ ч тэгсэн байж магадгүй.

Иван Григорьевич намын доторх маргалдаан тэмцэлдээнээс хэзээ ямагт хөндий байдаг билээ. Гэхдээ бусадтай хоолой нийлүүлэн бялдуучлан магтах ажилд ч бас оролцоогүй. Сталины хувьд энэ л хангалттай байжээ.

Будягин амьдралаа сайжруулах гэсэндээ хувьсгалын үйл хэрэгт оролцсон биш билээ. Эцэг нь ч, ах дүү нар нь ч, өөрөө ч цөм Мотовилихийн үйлдвэрийн сайн дархчууд учир тэднийх харьцангуй хангалуун аж төрдөг байжээ. Мотовилихийн үйлдвэр сангийнх, өөрөөр хэлбэл улсынх агаад дотооддоо хамгийн хүчирхэгийн нэгэнд тооцогддог, тавин тоннын алхыг нь дэлхийд дээгүүр орно гэлцдэг. Кама голын зүүн эрэг дээр гол төмөр замын дагуу оршдог Мотовилиха өөрөө бол Пермь хотын аж үйлдвэр, худалдааны дагуул, ажил явдал өрнөсөн, аж төрөл хангалуун, согтуу хөлчүү харьцангуй бага хот.

Нуман цахилгаан гагнуурыг бүтээсэн Николай Гаврилович Славянов тэр нэгэн ажилчин залуугийн авьяасыг хэнээс ч түрүүн таньж цахилгаан гагнуурын анхны ажилд татан оролцуулжээ. Тэр үеийн тэргүүний техниктэй гардан харьцаж түүнийг бүтээгчдийн гарамгай төлөөлөгчидтэй уулзсан явдал залуу хүүгийн сэтгэл санааг дэвэргэсэн байна. Үйлдвэрийн сэхээтнүүд болон хотод байгаа улс төрийн цөллөгийнхөн дотор социал-демократууд олон байсан учир Будягин тэдэнтэй зам нийлжээ. Иван Григорьевич бас л жирийн нэгэн социал-демократ үзэлтэн болох байсан байх. Тэрээр боловсролын гэрчилгээнээс гадна дээд сургуульд орох эрх олгодог Томскийн технологийн дээд сургуулийн дэргэдэх ерөнхий боловсролын курст бүртгүүлсэн байв. Гэтэл Оросын анхдугаар хувьсгал түүнийг мэргэжлийн хувьсгалч болгожээ. Тэр 1905 оны арван хоёрдугаар сард эхлээд бүх нийтийн улс төрийн ажил хаялтад, дараа нь цэргүүдтэй тулалдсан зэвсэгт мөргөлдөөнд оролцов. Тэгээд баривчлагдаж Нарым руу цөлөгджээ.

Хаант засгийн эсрэг тэмцэж байхад бүх юм Будягинд ойлгомжтой байлаа. Хувьсгал ч гэсэн бас ойлгомжтой байсан, хаант засгийг унагаах нь тэдний тэмцлийн эцсийн зорилго, тэдний үзэл санааны ялалт болох ёстой. Хэдэн зууны турш дарлан мөлжигчдийн эсрэг ард түмний уур хилэн асан дүрэлзэж, хувьсгалыг хамгаалах зайлшгүй зорилго байлаа.

Иргэний дайн дуусаж бүх юм байр байрандаа орлоо. Эдийн засгийн шинэ бодлого (ЭЗШБ)[7] зөвхөн эдийн засгийн шинэ бодлого төдийгүй амьдралын шинэ хэвшил байлаа.

Гэтэл Лениний “буурьтай, олон жил” хийхээр товлож байсан зүйл тун ахархан хугацаанд үргэлжиллээ. Сталин Лениний гэрээсийг биелүүлж байна гэдэг нэрийн дор ЭЗШБ-ыг устгалаа. Тэрээр Лениний нэрээр андгайлах, түүний нэрийг барих тун дуртай. Уул нь бүр Сибирьт байхынх л Ленин Оросыг хангалтгүй мэдэж байгаа учраас газрыг улсынх болгох лоозон дэвшүүлсэн гэж Иван Григорьевичид ярьдаг байсан юм. Энэ лоозонг тариачид хүлээж авахгүй гэж Сталин тэгэхэд зүтгэдэг байжээ. Бас Царицынд байхдаа мань хүн Ленин цэргийн хэргийг бага мэднэ гэж Будягинд биечлэн ухуулж байсан юм. Гэхдээ Лениний ач холбогдол,

намд гүйцэтгэж байсан ролийг нь Сталин ямагт ойлгож, хэзээ ч түүний эсрэг ил зөрж байгаагүй билээ. Эцсийн бүлэгт Лениний зөв байсан гэдэг нь мэдэгдэхэд ер нь дандаа л түүний зөв болдог л доо, Сталин өөрийгөө Лениний бодлогыг эргэлзэхгүй хэрэгжүүлж байсан үзэл нэгтэн гэж зарлана. Тэгээд одоо ч гэсэн алхам тутамдаа Лениний нэрээр андгайлж, өөрийгөө Лениний шийдвэрийг бараг санаачлагч, зоригжуулагч байсан мэтээр дүрсэлнэ. Гэвч Лениний бий болгохоор зорьж байсан социалист ардчиллын оронд Сталин шал өөр дэглэм бий болголоо.

Иван Григорьевич Сталиныд сүүлчийн удаа ирснээс хойш түүний жижигхэн байранд юу ч өөрчлөгдсөнгүй.

Сталин гэртээ ганцаараа, хоолныхоо ширээний ард сууж байлаа. Ширээн дээр нэг лонх Атенийн дарс, хундага, багвартай жимс, хоёр шил нарзан, дэлгээтэй ном энэ тэр байна. Сталин гэртээ цэрэг маягийн хувцас өмсдөг агаад хөх ягаандуу угалзтай цайвар илгэн гуталд өмднийхөө түрийг даржээ.

Тэрээр эргэж харав. Хацар, эрүү нь захны даавууны нарийн цагаан зурвасыг халхалж, цэрэг цамц нь гэдсэн дээр нь дэрдийсхийжээ. Нарийхан магнай, танил нөрөө, зөөлөн гоё гар. Энэ уулзалт тэдний эцсийн уулзалт гэдгийг Будягин ойлгож байлаа.

Сталин зугуухан босоод гараа өгөхгүй Будягиныг яг эгцлэн ширтсээр байв. Тэрээр нуруугаар нам ч гэсэн өлийх битгий хэл чигээрээ ч харахгүй, нэвсийн буусан дээд зовхио нэвт харж байх шиг санагдана.

Сталин хэзээ урьж суулгаж, энэ зохисгүй байдлыг дуусгах бол хэмээн Иван Григорьевич хүлээзнэв.

Сталин цонхны зүг толгой дохиж,

–Тэнд намайг зүхэцгээж байна уу? гэв.

Энэ бол Будягины сууж байгаад ирсэн орны ч тухай биш, энэ хоёрын одоо байж байгаа орны ч тухай биш, харин бүх дэлхийн тухай, бүх хүн төрөлхтний тухай, цонхны цаана байгаа бүх юмны тухай асууж байгаа хэрэг юм. Азийн нугаршгүй бурхан ингэж гэнэт Сибирийн модон байшинд байсан ганцаардмал, цөллөгийн гүрж болон хувирав. Одоо бол цонхны цаана бөглүү тайга биш түүний эрхшээлд орсон хэмжээгүй том орон тэр чигээрээ байна.

Их хурал дээр ялалт байгуулсныхаа дараа ингэж асууж байгаа хэрэг. Тэрээр хэнд ч итгэдэггүй хэвээр. Тийм учраас түүнд итгэдэггүй, сэжиглэж байдгийгаа зөв гэдгийг бас нэг мэдэж авах, Будягин мэтчлэнгийн хүмүүс яамаршуухан хүн бэ? гэдгийг дахин нэг шалгах гэсэн хэрэг. Мань хүн аль хэзээний Будягинд муудаж, дотроо ийнхүү анаж байгаа учраас инээх ч үгүй, гэр орныхных нь тухай асуусан ч үгүй, хуучин харилцаатай байсан гэх дүр хүний урманд үзүүлсэнгүй.

–Янз янз л байх... Зүхэж байгаа улс ч байнаа гэж Будягин өчив.

Сталин гараа дохих аядав. Иван Григорьевич суулаа.

Сталин гаансаа базсаар өрөөн дундуураа нэгэнтээ нааш цааш алхахад явдал нь хуучин янзаараа хөнгөхөн товолзуур байх ажээ.

–Рязанов ямар байна?

Санамсаргүй асуулт. Сталин Рязановыг хүлээж авч уулзсан. Улс төрийн Товчоон дээр сонссон, Төв Хороонд оруулсан. Дүү нь баригдсанаас болоод түүнд эргэлзэх сэтгэл төрсөн юм болов уу?

–Ажил хэрэгч, юмаа мэддэг хүн гэж Будягин хариулав.

–Хөндлөнгийн юм барих ажил сэдсэн гэж дуулдав уу?

Рязанов хотдоо кино театр, биеийн тамирын иж бүрэн барилга, тэрч ч байтугай “Уралын Мацеста” гэдэг рашаан амралтын газрыг дур мэдэн барьж байгаа тухай мэдээ Ардын комиссарын газарт ирсэн байжээ.

–Пятаков тийш нь комисс явуулсан гэж Будягин хариуллаа.

Сталин түүний нүд рүү эгцлэн харав. Ийм харц ямар учиртайг Будягин мэднэ. Энэ бол үл итгэснийг харуулж байгаа юм. Сталин түүний хариултад сэтгэл ханасангүй. Яагаад тэр вэ? Будягин үнэнийг нь хэлсэн шүү дээ. Гэвч Сталин итгэхгүй байх шалтаг алга байхад үл итгэснээ үзүүлэх буюу эргэлзэх үндэстэй байхад итгэж байгаа дүр харуулж нөгөө хүнээ балмагдуулдаг аргатайг Будягин сайн мэдэх билээ.

Сталин зугуухан хараа буруулаад жишлэн хямсайв.

–Серго Рязановыг Төв Хороонд оруулахыг санал болгосон. Төв Хороог гагцхүү аж ахуйхнаар бүрдүүлэх юм гэнэ.

Тэгээд Будягины яахыг хүлгэлзэн чимээгүй болов. Ийм л араншинтай хүн дээ. Оржоникизе Рязановыг Төв Хорооны бүрэлдэхүүнд оруулахыг санал болгосон хэрнээ Будягиныг санал болгоогүй гэж байгаа ёоз нь тэр.

Тэгснээ дуугаа өндөрсгөн үргэлжлүүлэв.

–Сергог бид хичнээн хүндэлдэг ч гэсэн Төв Хороог Улс ардын аж ахуйн Дээд зөвлөлийн Тэргүүлэгчдийн газар болгон хувиргаж чадахгүй. Манай намын Төв Хороо бол аж ахуйнхан, улс төрийнхөн, цэргийн ажилтан, соёлын зүтгэлтний төлөөлөгчдөөс бүрдсэн чуулган юм. Төв Хороонд манай намын аль ч хүчний төлөөлөгч орсон байх ёстой. Ялангуяа залуу хүчнийх.

Тэрээр Будягины өөдөөс харж зогсов.

–Зай гаргаж, ард түмний дундаас гарсан хүмүүст зам тавьж өгөх хэрэгтэй. Ард түмэн

улсынхаа толгойд өөрийн хөвгүүдийг байлгахыг хүсэж байна, шинэ язгууртнууд, явуулын шинэ хүмүүс байлгахыг хүсэхгүй байна. Оросын ард түмэн язгууртанд дургүй. Оросын ард түмний түүх бол язгууртны эсрэг тэмцсэн түүх юм. Оросын ард түмэн Догшин Иван, Нэгдүгээр Пётр энэ тэрд хайртай байсан, өөрөөр хэлбэл чухамхүү тайж, язгууртан нарыг устгаж байсан тэр хаадыг хайрлаж байсан. Болотниковоос эхлээд Пугачёвыг хүртэлх тариачдын бүх хөдөлгөөн бол сайн хааны төлөө, тайж язгууртны эсрэг хөдөлгөөн байсан юм.

Түүний ярьж байгаа юмыг энгийн түүхийн халил гэж үзэж болно. Тэрээр түүхийг мэднэ, ялангуяа сүм хийд болон сүм хийдийн тэрс үзлийн түүхийг сайн мэднэ. Гэхдээ түүний ярьсныг Будягин шиг ахмад зүтгэлтнүүд бол чухамхүү тэр шинэ язгууртнууд нь юм байна гэж ойлгосон ч бас болно. Ард түмэн тэднийг цаашид хүсэхгүй байж таарах нь.

Сталин үргэлжлүүлэн ярив.

–Төв мужуудын тариачид хувьсгалыг дэмжсэн байхад яагаад зах хязгаарын нутагт, жишээлбэл Сибирьт дэмжсэнгүй вэ? Тивийн мужуудад тариачин эр газрын эзэд язгууртнуудыг олж харсан, гэтэл Сибирьт тийм язгууртан байгаагүй юм. Тэгээд Колчак гэдэг язгууртан гараад ирэхтэй зэрэг тариачин эр хувьсгалыг дэмжсэн байна.

Сталин Будягиныг харлаа. Нүднийх нь гал буурч хүрэн нүдтэй болжээ. Дараа нь цонх руу очиж, цаашаа харсан чигээрээ,

–Гэхдээ залуу хүн болгон ШИНЭ хүч биш. Би зун нэг удаа Арбатаар машинтайгаа явж байгаад харсан чинь нэг байшингийн буланд гадаадын цув өмссөн хийх юмгүй хэсэг залуучууд инээлдэж байсан. Тэгэхлээр тэдэнд зөвлөлт эх орон, гадаадын цув хоёрын аль нь эрхэм зүйл вэ? гэдэг асуулт гарч байна гэв.

Залуу хүмүүсийн тухай яриа өдөөлөө. Тэгэхлээр Сашагийн төлөөнөөс тавьсан хүсэлтийнх нь тухай мань хүн мэдэж байх нь.

–Гадаад цув өмсөхийн хамт зөвлөлт эх орондоо хайртай байж болно гэж Будягин хэлэв.

–Чи тэгж санаж байна уу? гээд Сталин түүн рүү эргэж,

–БИ ТЭГЖ санахгүй байна. МИНИЙ хүүхдүүд гадаад цув өмсдөггүй, МИНИЙ хүүхдүүдэд манай зөвлөлтийн цув сайхан байдаг юм. МИНИЙ хүүхдүүдэд гадаадын цув олох газар байхгүй. Тэгэхлээр ТЭД НАР хаанаас олж байна? гэдэг асуулт гарч байна.

Энэ чинь Ленаг хэлж байгаа юм биш биз? Хэн нэг этгээд “Будягины охин гадаад даашинз өмсдөг” гээд алтан хошуу өргөсөн байх. Сталин яль шаль юмыг хэзээний их тоодог, хэрэг болгож тогтоож аваад, өөрийнхөө юм мэддэгийг харуулах гэхээрээ түүнийгээ гаргаж ярьдаг, аар саар юмыг нэгтгэн базаж, тэдгээрээс дүгнэлт хийж чаддагаараа бахархдаг билээ.

Будягин бараг арван жил гадаадад суусан болохоор тэдний гэр бүлийнхэн мэдээжээр тэндээсээ хувцас авдаг байсан гэдгээ ойлгуулж,

–Миний энэ өмсөж яваа ч гэсэн гадаадын костюм гэж хэлэв.

Сталин тэр санааг нь ойлгоод доогтойхон хүндэлж байгаа янзтай хоёр гараа дэлгэв.

–За-аа... Чи чинь манай олон улсын хэмжээний зүтгэлтэн шүү дээ, бид нар чамтай яаж барьцах вэ дээ...

Тэрээр Будягин руу аажуухан дөхөж ирээд гэнэтхэн гараа сунгаж толгойд нь хүрэв.

–Цэл залуугаараа байна, хав хар үстэй, сайхан..

Сталины энэ гар хүрсэн толгойг ямар амархан тасдаж хаяж болохсон бол гэж Будягинд бодогдов. Сталиний түүний бодлыг яг ойлгосон мэт гараа буулгахад уруул нь хямсганан жуумалзах шиг болов.

–Иван, чи ч хэзээ язааны зөрүүд, яахаас ч буцахгүй засаршгүй маргаанч хүн дээ.

Тэрээр дахин цонх руу очиж, мөн л цаашаа харсан чигээрээ дахиад яриагаа үргэлжлүүлэв.

–Бид манай залуучуудад хайртай, залуучууд бол манай ирээдүй. Гэхдээ тэднийг хүмүүжүүлэх хэрэгтэй, Цэцэрлэгч хүн модоо арчилж ургуулдгийн адил залуучуудыг өсгөж бойжуулах хэрэгтэй. Залуучуудад саймширч ая тал засахын хэрэггүй, тэдний алдааг өршөөж болохгүй...

Нээрэн, Сашагийн тухай л ярьж байна даа. Юу мэддэгээ үзүүлж байна. Мэдлэгийнхээ өчүүхэн хэсгийг үзүүлж байна. Харин шаардлага гарвал бүгдийг нь гаргаад ирнэ.

–...Залуучуудын дунд худлаа нэр төр олж авах гэж хөөцөлдөхийн хэрэг байхгүй. Худлаа нэр төр хөөцөлддөг удирдагчид ард түмэн дургүй. Ленин тэгж хөөцөлдөж байгаагүй, гудамжаар хэсүүчилж явдаггүй байсан. Сайхан ярьдаг бэлэн амтай удирдагчдад ард түмэн дургүй, Троцкий ямар сайхан ярьдаг хүн байлаа, гэтэл түүнээс юу үлдээд байна?

Энэ ч Киров руу харвасан бөмбөлөг болж таарлаа. Киров Ленинградын гудамжаар явган явдаг, Киров намын хамгийн уран илтгэгч. Харин энэний цаана юу нуугдаж байна вэ? Үгүй ээ, энэ хүн одоохондоо Киров, Оржоникизе хоёроос татгалзах болоогүй. Цаг нь болоогүй байна. Одоо бол Киров, Оржоникизе хоёртой бүр Астраханийн хамгаалалт, Хойт Кавказын байлдааны ажиллагааны үеэс ойр дотно болсон хүнийх нь хувьд Будягинаас эхэлж, түүнийг тэмтэрч үзэж байна. Түүний тулд л дуудаж л дээ. Олон улсын асуудал түүнд падгүй юм байна. Хэрвээ сонирхох байсан бол жилийн өмнө дуудах шүү дээ.

Сталин урьдын адил ойр дотнынхоо хүмүүсийн талаар ингэж илэн далангүй ярьж байгаа, бас үгийг нь цааш нь дамжуулахгүй гэж бат итгэж байгаа нь үнэхээр гайхаш төрүүлнэ. Будягин энд сонссон юмаа Кировг ч юм уу, Сергод ч юм уу дурсах төдий хэллээ гэхэд л түүнийг хутган үймүүлэгч хэмээн дор нь гутам шиг болгоно. Сталин муу юм ер хэлээгүй юм чинь. Гагцхүү Оржоникизе Төв Хороонд аж ахуйн хүмүүсийг байлгах эрмэлзэлтэй байгааг дурдаж, Кировын Ленинградын гудамжаар ил чөлөөтэй явж байдагт зүй ёсоор санаа зовж буйгаа л хэлсэн шүү дээ.

–Ингэхэд Кодацкий чинь ямар хүн бэ? Чамайг Астраханьд байхад тэнд байсан байх аа? гэж Сталин эгцэлж харалгүй асуув.

–Тийм ээ байсан. Мужийн загасны аж ахуйг эрхэлж байсан. Чи бодвол түүнийг бас мэдэх байлгүй, тэр чинь Ленинградын хотын зөвлөлийн дарга.

Сталин энэ хариуны далдуур өгсөн утгыг анзааралгүй дүр гарган,

–Гэтэл Кодацкий чинь Зиновьевын талыг баримтлагч шүү дээ гэж тайван хэлэв.

Будягин үнэн санаанаасаа гайхлаа.

–Кодацкий юу? Тэр чинь Зиновьевын эсрэг л тэмүүлж байсан даа.

–Тийм, тэмцэж байгаа юм шиг байсан... хэмээн Сталин үгийг нь дагуулснаа,

–Харин Ленинградын ажилчид Троцкий, Зиновьев хоёрыг намаас хөөх шаардлага тавихад нөхөр Кодацкий нэг их баярлаагүй шүү. Гуйвж байсан. Тийм чухал асуудал дээр тэр шүү дээ! Тийм болохтойгоо зэрэг нь түүнийг Москва-Нарвын районы намын хорооны нарийн бичгийн даргын албан тушаалаас чөлөөлөхийг нөхөр Киров өөрөө санал болгосон юм. Тэгээд чөлөөлсөн. Улс ардын аж ахуйн зөвлөлд нэг хэсэг байлгасан. Гэтэл одоо Ленинград хотын зөвлөлийн даргаар дэвшүүлжээ. Ленинград хотын зөвлөлийн дарга Григорий Зиновьевын оронд шинэ дарга тавьсан нь бас Зиновьевын талыг баримтлагч. Үүнийг Ленинградын ажилчид юу гэж үзэх ёстой вэ? гэв.

–Миний л мэдэхээр бол Кодацкий эсрэг бүлэгт оролцоогүй. Хэрэв тэр зохион байгуулалтын асуудал дээр гуйвж байсан бол тиймэрхүү гуйвалт найман жилийн өмнө битгий хэл одоо ч гэсэн хэн дээр ч гарч болох зүйл гэж Будягин хэлэв.

–Кодацкийн цусыг үзэх гэсэн хүн байхгүй гэж Сталин хэнэггүй өгүүлээд Будягин руу эргэж,

–Гэлээ ч гэсэн Ленинградынх шиг намын байгууллага бол боловсон хүчнийг шилж сонгохдоо аль болох хянуур болгоомжтой хандах хэрэгтэй юм. Гэвч нөхөр Киров өөрийнхөө үзэмжээр туслагчдаа сонгож авч байхыг манай нам түүнд итгэмжлэн хариуцуулсан. Хөндлөнгөөс оролцохоо больё гэв.

Энэ сүүлчийн үг бол Кодацкийн тухай яриа албаных биш хувийн чанартай яриа байсан гэдгийг сануулсан хэрэг юм. Тэгээд Сталин уулзалтыг дуусгахын тулд зөвхөн ёсыг бодож Будягины хүлээж байсан асуултыг асуув.

–Гитлер юу вэ?

–Гитлер бол дайн гэсэн үг гэж Будягин хариулав. Сталин хэсэг зуур чимээгүй байснаа,

–Тэр чинь юугаараа байлдах юм бэ? гэж асуув.

–Германы аж үйлдвэрийн хүч бололцоо лут. Тэднийх зэвсэглэхэд хэцүү биш.

–Гитлерийг зэвсэглэхийг хэн зөвшөөрөх билээ?

–Тэр ч зөвшөөрөл авахгүй л дээ.

–Засгийн эрхэнд тогтох уу?

–Тогтох нь л дээ.

Сталин дахин чимээгүй болж хуруугаараа захныхаа дотуур нэгэнтээ шудрав.

–Герман хүмүүс байлдах уу?

–Албадвал байлдаж л таарна.

Сталин зугуухан нухацтайгаар,

–Англи, Франц хоёр Германд Версалийн гэрээ, дайны төлбөрийг тулган хүлээлгэж нүцэглэж дөнгөсөн, Судеты, Данциг, Польшийн зурвас, колони зэргийг булаан авч, Зүүн Пруссийг тасадсан. Германиуд хэнтэй байлдах санаатай байна вэ? гэж өгүүлэв.

–Англи, Франц хоёр манай юмаар Германтай наймаалцахыг оролдоно.

Сталин Будягин руу эргэв. Түүнд бүх юм тодорхой болжээ. Будягин өөрийнхөө бодлыг нуух хэрэгтэй гэж үзэхгүй байгаа төдийгүй тэр бодлоо энд, өөрийнх нь өмнө, өөрийнх нь гэрт хэлэх ёстой гэж үзэж байх нь.

Гэвч мань хүн гаднаас харахад тайван байдлаа хадгалан,

–Англи, Франц хоёр Европын зүрхэнд хэзээ ч хүчирхэг Герман улсыг бий болгохгүй. Харин бид бол тэс өөр сонирхолтой, Англи, Францыг сөргүүлж хүчирхэг Герман улс байлгах сонирхолтой гэв.

–Бидний хувьд Герман бол яг бодитой аюул мөн гэж Будягин итгэл дүүрэн хариулав.

Сталин хөмсөг зангидав.

–Германы аюулыг дэвэргэнэ гэдэг бол гол аюулыг басамжилна гэсэн үг. Английн империалистууд үүнийг тэгээсэй гэж байгаа нь гарцаагүй. Харин зөвлөлтийн хүмүүс, бид нар бол үүнийг тэгээсэй гэж хүсэхгүй байна.

–Би ч өөрийнхөө бодлоор л байна гэж Будягин өгүүлэв.

–Тийм учраас л чи нөгөө байсан газраа байхгүй байгаа юм гэж Сталин Будягинаас хараа салгалгүй хэлэв. Будягин түүний харцнаас огтхон далдирсангүй.

Сталин хэсэг зуур дуугүй байснаа Будягин руу харалгүй, өөр хэн нэгэн хүнд хандан өгүүлэх мэт,

–Завсрын үзвэрээр гайхуулах явдал намд хэрэг байхгүй. Намд ажил хэрэгч үйл ажиллагаа хэрэгтэй. Үүнийг ойлгодоггүй хүн намд хэрэггүй гэв.

–Би намд хэрэгтэй эсэхийг нам шийднэ биз гэж Будягин өчив.

Сталин ширээ рүүгээ буруу харж суугаад гартаа ном авлаа.

–Би ажилтай байна. Уучлаарай.

Будягины араас хаалга хаагдлаа. Сталин номоо хажуу тийш нь тавьж босоод гансаа бариатай чигээрээ өрөөн дундуураа явж цонхны дэргэд очоод Арсеналын ганил цагаан шаргал барилга, түүний урдуур тавилсан зэс их буунууд руу харав.

Мотовилихаас төрсөн дипломат! Жинхэнэ аюул бол зэвсгээ хураалгасан Герман биш, манай Алс Дорнодын ар талд Манжуурт байгаа японы цэрэг. Будягин хичнээн хомс ухаантай ч гэсэн үүнийг бас ойлгож байгаа. Тэгээд ч Гитлерээс болж сая ирсэн юм биш. Намын дотор өөрийн гэсэн бодолтой, тэр бодлоо хадгалж байгаад хэрэгцээтэй мөчид түүний үзэл бодлын эсрэг сөргүүлж тавих эрхтэй хүн байгаа гэдгийг мэдэгдэх гэж ирсэн. Тэрээр өөрийнхөө мэдлээр ирээгүй, тэгж ирнэ гэхэд дэндүү өчүүхэн амьтан. Даалгаврын дагуу ирсэн. Эсрэг хүчнээ бут ниргэхэд нь Сталинд өөрт нь тусалсан гээд байгаа, бас өөрийнх нь түшиж тулсаар ирсэн, цаашид ч түшиж тулж байх ёстой гээд байгаа, эс тэгвээс нөгөө эсрэг хүчнийг зайлуулсан шиг өөрийг нь адилхан зайлуулчихна гээд байгаа нөгөөдүүлийн дундаас ирсэн. Өөрийг нь тэдний хүчинд л ийм яваа гэж тэд итгэж байгаа.

Тэд ихээхэн эндүүрч байгаа юм. Жинхэнэ жолоодогч бол ӨӨРӨӨ ирдэг, ӨӨРИЙНХӨӨ хүчинд л тийм засагтай байдаг. Эс тэгвээс тэр хүн бол жолоодогч биш зөвхөн төлөөний хүн. Тэд түүнийг сонгож аваагүй тэрээр өөрөө тэднийг сонгож авсан. Тэд түүнийг ураг нь түлхэж гаргаагүй, тэрээр өөрөө тэднийг араасаа татаж гаргаж ирсэн. Тэд түүнд байр сууриа олж батжихад нь туслаагүй, тэрээр өөрөө тэднийг төр засгийн өндөрлөг хүртэл өргөж гаргасан. Тэд энэ зэрэгтэй байна гэдэг чинь хажууд байсан болоод тийм болсон хэрэг.

Ленин хэний ачаар тийм болсон бэ? Лондон, Женевийн цагаачдын ачаар уу? Пётр хэний ачаар вэ? Меньшиковын ачаар уу? Лефортын ачаар уу? Засаг өвлөнө гэдэг бол уг хэргийн жинхэнэ учрыг өөрчлөхгүй. Хаан хүн жолоодогч болтлоо асахын тулд өөрийг нь гар хурууны үзүүрийн тоглоом төдийд тооцдог хүрээлсэн хүмүүсээ устгах ёстой. Пётр ч тэгсэн, Догшин Иван ч тэгсэн.

Тэрээр эсрэг этгээдүүдээ бут ниргэж чадсандаа жолоодогч болсон юм биш. Харин жолоодогч байсан учраас эсрэг этгээдүүдээ бут ниргэсэн юм. Чухамхүү тэрээр улс орныг жолоодохоор заяажээ. Эсрэг этгээдүүд нь үүнийг ойлгохгүй байсан учраас бут цохигдсон, тэд үүнийг одоо хүртэл ойлгоогүй байна, тийм учраас бүрмөсөн устгуулах болно. Бүтэл муутай өрсөлдөгч ямагт далдын дайсан байдаг.

Тэрээр энэ орны дээд засгийг барих нууцыг ганцаараа эзэмшсэн, энэ ард түмнийг яаж удирдахыг ганцаараа мэдэж байсан, түүний ололт дутагдлыг, юуны өмнө дутагдлыг нь бүрэн мэдэж байсан учраас түүх түүнийг сонгон авчээ.

Оросын ард түмэн бол хамт олны ард түмэн. Хэзээ язаанаас нийгэмлэгээрээ аж төрж ирсэн түүхтэй, тэгш эрх үндэсний зан чанарынх нь суурь болсон ард түмэн юм. Энэ нь түүний Орост байгуулж байгаа нийгэмд таатай нөхцөлийг бүрдүүлж өгч байна. Лениний Эдийн засгийн шинэ бодлого тактикийн хувьд зүйтэй арга байсан боловч “буурьтай, олон жил” явуулна гэснээр алдаа болоод хувирчихаж байгаа хэрэг. Энэ арга бол тариатай болохын тулд

тариачинтай хийж буй түр зуурын наймаа. “Буурьтай, олон жил” гэдэг бол фермийн эздэд зориулсан бодлого, гэтэл фермийн эзэдтэй болно гэдэг чинь ард түмний сэтгэл зүйн аяст үл нийцэх эрх тэгш бус байдалд хүргэх юм. Сталин шүүгээ рүү очиж хуудсыг нь энд тэнд нь нугалсан Лениний нэг ботийг гаргаж дахин уншиж үзлээ. “Эдийн засгийн шинэ бодлогыг ашиглан хүн амыг толгой дараалан хоршоололд оролцуулахын тулд... Ингэхийн тулд түүхийн бүхэл бүтэн үе шаардагдана... Толгой дараалан бичиг үсэгтэн болохгүйгээр, зохих хэмжээний мэдлэггүйгээр, хүн амыг том хэвлэл зохих хэмжээгээр ашигладаг болгож сургахгүйгээр, мөн материаллаг үндэсгүйгээр, жишээлэхэд ургац алдах, өлсгөлөнд нэрвэгдэх зэргээс хамгаалах тодорхой хэмжээний хангамжгүйгээр, энэ бүхэнгүйгээр бид зорьсондоо хүрэхгүй юм. Тэрээр номоо хамхиад байранд нь тавилаа. Энэ бол тариачин эрийг түүнд харш фермийн эзний сэтгэл зүйд дасгах зам. Гэтэл фермийн эздэд пролетарийн диктатур хэрэггүй. Орос тариачны толгойд хувийн өмчтөн, хувийн үзэлтэн, фермийн эзэн болох санаархал үр хөврөлийн төдийд байхад л түүнийг нь сөнөөх хэрэгтэй. Хоршоолол уу? Тийм. Гэхдээ тариачин хүн ердийн ажилтан байх хоршоолол хэрэгтэй. Тэрээр үүнийг хэрэгжүүлсэн, тэгээд ч энэ нь Октябрийн хувьсгалаас дутахгүй Оросын хоёр дахь хувьсгал болсон юм. Яагаад гэвэл бид Октябрийн хувьсгал хийхэд тариачид бидний талд байсан, харин хамтралжуулалтын үед тэд бидний эсрэг талд байсан. Тийм ээ, ном судар, шинжлэх ухааны аль нь ч хэрэгтэй, ургац алдахын эсрэг ч тэмцэх хэрэгтэй... Энэ бүхэн цөм хэрэгтэй. Гэхдээ хамтралжуулалтын өмнө заавал байх ёстой бус, харин хамтралжуулсны үндсэн дээр бий болох ёстой.

Эхлээд хамтралжуулалт, дараа нь соёл. Тэрээр тийнхүү ёсоор болгожээ.

Лениний хүнд суртлын завхрал гэж нэрлэсэн тэр нэгэн зүйл бол удирдлагын тогтнон байж болох цорын ганц хэлбэр. Гэхдээ үүнд хүнд суртлын аппарат нь ард түмэн, дээд засаг хоёрын хоорондуур орохыг эрмэлзэж, дээд засгийг орлохыг оролддог нэг аюул бий. Үүнийг хайр найргүй тас цохиж байх хэрэгтэй. Аппарат бол дээдсийн хүсэл зоригийг баараггүй биелүүлэгч бөгөөд түүнийг байнга айлгаж байвал зохино, тэгвээс тэр айдас ард түмэнд дамжиж байх болно.

Тэрээр тийм аппараттай билүү? Үгүй! Байхгүй! Засгийн эрхийн төлөө тэмцэж байхад байгуулсан аппарат бол өөрийгөө ялалтын нэг эзэн гэж үздэг учраас жолоодогчийн гар хөл хараахан биш. Будягины саяын байж байгаа царай тэр тухай сануулга мөн.

Жинхэнэ жолоодогчийн аппарат гэж засгийн эрхэнд гарсныхаа дараа өөрөө биечлэн байгуулсан аппаратыг хэлнэ. Энэ аппарат бол үүрдийн буюу тогтмол байж болохгүй, тэгэх юм бол харилцан хэлхээ холбоогоо бэхжүүлээд нэгдэн нягтарч хүч чадалтай болно. Аппаратыг хольж сэлж, шинэчилж, өөрчилж байх хэрэгтэй.

Тийм аппаратыг байгуулна гэдэг бол өрсөлдөгчийгөө зайлуулахаас илүү төвөгтэй зорилт, яагаад гэвэл аппарат гэдэг чинь дээрээсээ доош хүртэл холбогдон гагнагдаж, нэгэн эд эс болж нягтарсан бум буман хүн. Одоогийн Улс төрийн Товчооны гишүүд бол нөгөө Ленинтэй хилийн чанадаас буцаж ирж байсан хүмүүс хэдийн биш. Эд нар бол аппаратын дотор дээрээс доош хүртэл нэвт сүвлэсэн хэлхээ холбоотой, гинжээр хэрээтэй улс, энэ гинжний нэг горхийг хөндөхөд л бүх гинж тэр чигээрээ харжигнаад явчихна.

Тэрээр хүрээлж байгаа хүмүүстээ итгэдэгсэн билүү? Улс төрийн бодлогод хүнд итгэх ёсгүй.

Молотов, Каганович, Ворошилов гурав биеэ даах гэж зүтгэдэггүй, сайн гүйцэтгэгч нар учраас бусдаас илүү найдвартай. Тэд шаардлагатай ажил явуулга хийх чадвартайгаа нотолсон, тэр ажил явуулгаараа өөрсдийгөө хүлээсэнд оруулсан, түүнгүйгээр тэд бол юу ч биш. Ворошилов урваж магадгүй, гэхдээ цэргийн сэхээтнүүд, ялангуяа Тухачевскийгээс айдаг учир өөрийнх нь хормойноос зүүгдсээр л байх болно. Ворошилов армийн дотор Будённый, Тимошенко, Щаденко, Городовиков нарын морин цэргийнхнийг түшнэ, гэтэл сэлэмний үе нэгэнт өнгөрсөн хойно энэ бол сулхан дэмжлэг.

Калинин, Андреев хоёр байна. Улс төрийн Товчооны хамгийн ахмад, хамгийн залуу хоёр гишүүн. Нэг нь тавин естэй, нөгөө нь гучин естэй дэвшигсэд. Калинин нь тариачдаас, Андреев нь ажилчдаас. Тэр хоёр олонхийг дагана.

Ингээд эцэст нь нөгөө найдваргүйчүүд. Энэ бол Киров, Оржоникизе, Косиор, Куйбышев, Рузутак нар.

Нөгөө гэрээслэл гэгдсэн тэр нэгэн захидлын үед Ленин Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд түүний оронд Рузутакийг тавихыг битүүдээ санал болгож байсан. Ленин энэ асуудлаар Рузутактай өөртэй нь зөвлөлдөж санал асууж бариагүй байж болно. Рузутак болгоомжтой байгаа хүн. Тэрээр Лондонгийн их хурлаас хойш Хоёрдугаар сарын хувьсгал хуртэл бараг арван жил хүнд хүчир албаданд тарчилсан учир аппаратын дотор олигтой хэлхээ холбоо байхгүй. Гэлээ ч гэсэн энэ бол Ленин түүний оронд тавих гэж байсан хүн. Энэ тухай мартах ёсгүй. Энэ тухай Рузутак өөрөө ч гэсэн мартахгүй. Куйбышев бол язгууртан гаралтай, кадетийн корпус[8] суралцаж байсан хүн. Биеийн жаргал хөөгч. Хувийнхаа амьдралд толгой мэдүүлсний гадна бие муу, өөрийг нь битгий зовоогоосой гэсэн бодолтой байгаа. Уул нь сайн ажилтан, гэхдээ манай намд өөр сайн ажилтнууд олдох л доо.

Косиор ирдэг байсан, хонгилоор түүнтэй явж байхдаа хоёр талд нь гүйж гараад байсан. Яагаад тэгж гүйгээд байв? Хуурамч хүн. Итгэл алга.

Оржоникизе. Энэ хэцүү. Гучин жилийн өмнө Тифлист танилцсан цорын ганц ойр дотнын хүн. Гэтэл чухам тэр дэндүү эртнээс мэддэг нь хэцүү, дэндүү олон янзын байдалтай явахыг нь мэднэ, бас өөрийгөө үзэл бодол нэгтэн гэж үздэг. Гэтэл жолоодогч хүнд үзэл бодол нэгтэн гэж байхгүй, гагцхүү хамтран зүтгэгч гэж байна. Талархан дагагчийг шавь нараасаа сонгодгоос биш анд найз нараасаа сонгодоггүй. Дэврэнгүй гэнэн цагаан сэтгэлтэй, итгэмхий, ярьж, хийж байгаа юмандаа дэндүү үнэн санаанаасаа итгэнэ. Улс төрийн бодлоготны хувьд аюултай шинж чанар. Эсрэг бүлгийнхнийг бууж өгсний дараа тэднийг цөмийг нь намд буцааж авахыг санал болгож байсан.

Түүний эсрэг тэмцэж байсан бүх хүнийг устгах ёстой гэдгийг ойлгохгүй байлаа гэж үү? Түүний эсрэг тэмцэнэ гэдэг бол Зөвлөлт засгийн эсрэг тэмцсэн хэрэг гэдгийг ард түмэн мэдэж байх ёстой. Энэ Зөвлөлт засгийн дайснуудыг намын гадна биш, намын дотор байхад нь мань хүн яагаад устгая гэсэнгүй вэ? Энэ бол алдаа биш, харин чиг шугам. Энэ бол намд түүний эсрэг хүч байлгах гэсэн хүсэл, цаашид ч өөрөө шүүгч хэвээр байж, хэрэгтэй цагтаа түүний эсрэг сэргүүлж тавьж болох нөөцтэй байх гэсэн эрмэлзэл.

Үүний баталгаа нь Ломиназе. Ломиназегийн Шацкинд бичээд 1930 онд замдаа олзлогдсон

захидлын тухай Серго мэднэ. Яажшуухан хүлээж авлаа даа? Дал мөрөө хавчсан... “Нялх хүүхэд...” Гэтэл тэр “нялх хүүхэд” нь захидалдаа түүний тухай юу гэж бичлээ? Улс төрийн бодлогод хүүхдэрхэх гэж юм байхгүй, улс төрийн бодлого бол хүүхдийн тоглоом биш. Ломиназе, Шацкин хоёр өөрсдийгөө үе залгамжлагчаар бэлтгэж яарцгааж байсан. Гэтэл Ломиназе гэж хэн билээ? Төрснөөсөө гуравхан жилийн өмнө төрсөн бол нөгөө Жордания, Чхеизе, Церетели мэтийн меньшевикуудтай нэг тэргэнд байж байхсан. Тэд бас түүнийг балар харанхуй хүн гэж үздэг юм чинь. Энэ хэдэн гүрж сэхээтэн бол гүржийн үндэсний араншингаас хамаг өөдгүйг нь өөртөө шингээсэн хүмүүс. Өөрсдийгөө Ази тив дээр байгаа европ маягийн арал гэж үзнэ. Одоо Ломиназе Уралд байгаа, гэтэл Серго түүнийг урьдын адил ивээлдээ байлгасаар байна. Санаандгүй зүйл мөн үү? Санаандгүй зүйл биш. Ломиназе бол түүний бодлогын нэг гархи.

Оржоникизе ийм бодлогыг ганцаараа явуулж байна уу? Ганцаараа биш. Энэ бол Киров тэр хоёрын нэгдсэн бодлого. Салж хагацдаггүй анд найз нар! Киров Москвад ирэхлээрээ гагцхүү Сергогийн бууна. Тэр хоёрын энэ нялуун нөхөрлөлийн цаана юу байна вэ? Тэднийг юу нэгтгээд байна? Улс төрийн зүтгэлтнүүдийн хооронд хувийн нөхөрлөл гэж юу байх вэ дээ? Улс төрийн Товчооны хоёр гишүүнд нөхөрлөлөөрөө бусдаасаа ялгарах хэрэг юу байна? Хоёулаа дөчин наймтай, хоёулаа Хойт Кавказ, Гүржид байсан, хоёулаа гучин оноос Улс төрийн Товчооны гишүүн байгаа, гэхдээ энэ бол тэгж хоёулхнаа ялгарах үндэс хараахан биш. Нөхөрлөл эн тэнцүүхэн байна гэж байхгүй. Нөхөрлөлд улс төрийн бодлоготой адилхан хэн нэг нь хөтөлж, нөгөө нэг нь хөтлөгддөг, хэн нэг нь нөлөөлж, нөгөө нь нөлөөлөгдөж байдаг. Энэ нөхөрлөлийн гол эзэн бол Киров. Аливаа хомс номтны адил эрх тушаалд шунамхай, аливаа хөдөөгийн барагтайхан сонинхон шиг хоосон цэцэрхэмтгийн дээр аливаа овжин хэлэмгий хүний адил өөрийг нь бараг л “Хувьсгалын дуудлага” гэх нь халаггүй, намын манлай уран илтгэгч хэмээн хүндлэн дээдэлдэг талархагчидтай.

Сталин Кировыг тухайн үедээ Ленинград руу явуулахдаа Ленинград бол хоёрдугаар нийслэл биш, улс орны баруун хойно байгаа ердийн нэг мужийн хот гэдгийг Ленинградынханд харуулах гэсэн юм. Хоёр нийслэлтэй болж хэзээ ч таарахгүй, тэгэх юм бол хоёр дахь нь нэгдэхийнхээ байнгын өрсөлдөгч болно. Ленинградынхан нэр цуутай хүмүүст сурчихсан улс. Гэтэл тийшээ алс холын Азербайжанаас бараг хэн ч мэдэхгүй Киров очлоо. Ядахад Улс төрийн Товчооны гишүүн ч биш. Питерийн ажилчид хувьсгалч үүх түүхээрээ омойтдог улс, гэтэл тэдэн рүү хувьсгалын өмнө “Терек” хэмээх ердийн нэгэн жижигхэн сонинцорын ажилтан агсан хүнийг явуулсан хэрэг. Эсрэг булгийнхний хуйвалдааныг үндсээр нь таслан устгуулахаар аль нэгэн хөндлөнгийн томилолтын хүний байдлаар явуулсан хэрэг. Уул нь үүнийг Ленинградынхан хүлцэн тэвчихгүй, тэгээд байдал улам хурцдаж, тэр хэзээ ямагт сөрж зөрж байдаг төвийг бүрмөсөн устгах нөхцөл бий болно гэж тооцож байжээ.

Киров Ленинградад найман жил суухдаа тэнд дасан идээшиж, тэднийхний “хайртай” хүн болоод намын байгууллагаар өөрийгөө нягт хүрээлүүлж, Ленинградыг чухамхүү улсын хоёрдугаар хотынх нь хувьд ач холбогдлыг нь улам бэхжүүлсэн. Тэрээр Ленинградын хэзээнээс бие даах гэдэг санаархлыг дэмжиж, тэдний хот Оросын цорын ганц европ маягийн онцгой хот гэсэн инээдэмтэй муйхар итгэлийг тэтгэж байгаа юм. Нэр төр олж авах гэж байж ядахдаа хээгүй хүн болох гэж цөхөж байна. Каменноостровскийн өргөн чөлөөний хэн хамаагүй хүн суудаг нэг том байшинд байртай, ажил руугаа явган ирж очно, хотын гудамжаар

сэлгүүцнэ, машиндаа хүүхдүүд суулгаж давхина, тэдэнтэй хашаан дотор “муур хулгана болж” тоглоно...

Хамтран зугтгэгч бол жолоодогчоосоо үлгэр авч түүнийг дуурайх ёстой. Жолоодогчийн аж төрж байгаа янз бол түүний биелэл болж байгаа эрин үеийн янз, түүний удирдаж байгаа тэр улсын янз. Киров энгийн өөриймсөг зангаа өмнөө барьж байгаа явдал бол Сталин Кремльд хамгаалалттай аж төрдөг, гудамжаар явган явдаггүй, хүүхдүүдтэй “муур хулгана болж” тоглодоггүй гэдгийг зориуд харуулах гэсэн хэрэг, бас Сталин бол ард түмнээсээ айдаг, Киров бол айдаггүй гэдгийг цохох гэсэн хэрэг, ингэснээрээ түүнийг дайрч байгаа хэрэг юм.

Киров Арван долдугаар хурал дээр “Ленинградад гагцхүү Петербургийн ажилчдын яруу алдарт хувьсгалч уламжлал нь хуучнаараа үлдсэн, бусад бүх юм шинэ болсон...” гэж хэлсэн.

Шал худлаа! Ленинградад хувьсгалын өмнөх түшмэд, язгууртнууд, хөрөнгөтний сэхээтнүүд үлдсэн, хөрөнгөтний тагнуулын газрын туршуул литва, эстон, финн, германчууд бас үлдсэн, өөрийгөө Октябрийн хувьсгал хийгчид гэж сэтгэж байгаа бэртэгчин ажилчид, Зиновьевын намын эсрэг довтолгооныг дэмжиж байгаа хэдэн түмэн хүн тэнд аж төрж байгаа. Ленинградын намын байгууллага Зиновьевыг дэмжиж коммунистууд, комсомолчид эсрэг бүлгийнхний төлөө санал өгцгөөж байсан. Тэд нар хаачсан байх вэ? Тэд нар эрүүл саруул аж төрцгөөж байгаа, тэд одоо ч гэсэн Ленинградын намын байгууллагын олонхи хэвээр байгаа. Ёзоор нь үлдсэн, тийм ёзоор зөндөө бий. Киров яагаад тэднийг булгалж хаяхгүй байна вэ? Зиновьевын эсрэг тэмцсэн Чудов, Комаров бас бус хэдэн нөхдийн нэрийг заагаад байгаа юм. Гэтэл тэд яагаад тэмцсэн юм бэ? Зиновьев тэднийг гомдоосон, тэгээд л түүний эсрэг босоо шүү дээ. Мунхаг толгойнууд! Зиновьев үүнийг ойлгож байсан учраас тэднийг урагш нь алхуулахгүй байсан юм. Тэгэхлээр өөрөө ч бас тэднийг урагш алхуулахгүй дээ, өөрийнх нь эсрэг муу юм хийх л улс. Гэтэл нөхөр Киров ийм хүмүүсээр өөрийгөө хүрээлүүлээд байгаа юм даа.

Юм ийм байхад гагцхүү хуучин хувьсгал ч уламжлал нь хуучнаараа үлдсэн гэж яаж хэлж болж байна вэ? Энэ бол Ленинградын ил далд, илчлүүлсэн, нуугдсан элдэв эсрэг бүлгийнхнийг улайм цайм хамгаалсан хэрэг, энэ бол Ленинградын бэртэгчин ажилчдад тал засаж, тэдний талархлыг улам хүлээж, Сталинаас тэднийг хамгаалж байгаагаа үзүүлэх гэсэн эрмэлзэл, энэ бол Ленинградын цайзыг өөртөө хадгалж үлдэх гэсэн оролдлого. Яг Серго шиг түүнд бас сөрөг тэнцвэр бэлтгэж байгаа нь энэ. Нэг тактик, нэг бодлого. Тэд Сталиныг мэхлэх юм гэнэ! Сталиныг мэхэлж чадахгүй ээ! Тэд түүнийг хичнээн магтаж дөвийлгөлөө ч гэсэн, нэрийг нь барьж хичнээн тангараг тавилаа ч гэсэн мэхэлж чадахгүй.

Тэрээр ноднин Кировтой нэг долоо хоног хамт байсан. Тэгэхэд Ворошилов бас тэдэнтэй цуг байсан. Цагаан далайн суваг руу явж, Сорок, Мурманск, Ленинградын усан буудлыг үзсэн. Киров Цагаан далайн сувгийг үзээд нэг их сүйд болохгүй байгааг тэгэхэд мань хүн анзаарсан. Гэтэл Хойт тэнгисийн зам гэдэг чинь Номхон далай руу, Японы ар тал руу очих гарц шүү дээ. Стратегийн энэ асуудлаар Киров Дорнодоор биш, өрнөдөөр баримжаалсан өөр байр суурьтай байна. Мань хүн үүнийг бас л Петербургийнхнээс өвлөж авч л дээ, тэд өөрсдийгөө европчууд гэж үздэг юм чинь. Тэрээр Будягинтай адилхан байр суурьтай байна. Ингэхлээр Будягин түүн рүү зүгээр нэг сануулах гэж ирсэн биш тодорхой зорилгоор ирсэн байх нь.

Киров баяр хөөрөө үзүүлж чаддаг хүн, гэтэл Цагаан далайн сувгийн тухайд юу ч үзүүлээгүй, тэгэх хэрэгтэй ч гэж үзсэнгүй. Юм хэлэхгүй байсан. Гэлээ ч гэсэн биеэ барьж чадаагүй. Мурманскийн усан буудлын дарга шинэ гүүрэн цамхгийг үзүүлж байхад Киров түүний тайлбарыг задалж ойлгуулах гэж оролдсон, өөрийнхөө давуутайг үзүүлэх гэж байгаа нь тэр. Тэр ч аргагүй л дээ! Шашны сургуульд биш, аж үйлдвэрийн дунд сургуульд суралцсан, механикч нэртэй юм чинь. Харин энэ хорин жилд нөхөр Киров, яагаад ч юм бэ, цорын ганц өдөр ч болохноо механикчийн ажил хийж яваагүй. “Терек” сонины ажил арай цэвэр байсан бололтой. Түүний техникийн дунд боловсролоос ямар ч ул мөр үлдсэнгүй, тэгэхлээр аль хэдийн мартсан, хуучирч хоцрогдсон мэдлэгээ олны нүдэн дээр гаргаж тавиад байхын хэрэг байхгүй. Техникийн сургууль хийгээгүй удирдагч учрыг нь олох гэж оролдож байхад техниктэй хальт мөлт танилцсан удирдагч дэмий чалчиж бусдыг сургах гэж оролдож байна. Энэ чинь хэнийг сургах санаатай байна вэ?

Тэгэхэд тэр, нэгэн үдэш Надя түүнийг “Тэд нар чамд нөлөөлж, засаж авч болно гэж бодож байдаг.. Ёстой гэнэн улс! Тэд нар чамайг даанч мэдэхгүй юм! Чамд ерөөсөө нөлөөлөх арга байхгүй, чи засаршгүй хүн...” хэмээн зүхсэн.

ТЭД гэдэг нь Надягийн хамгийн дотнын найз, Киров, Оржоникизе хоёр. Тэд нар л түүнийг тартагт нь тулгасан! Тэр хоёр! Тэд!.. Хүүхнээр нь дамжуулж өөрт нь нөлөөлөх санаатай байна, тэгээд хүүхэнд нь түүнд үл итгэх амьсгал бий болгосон. Улс төрийн хувьд богино жолоотой бүсгүй хүнийг ашиглаж өөрийг нь ийнхүү ар талгүй, ар гэргүй, авгай хүүхэдгүй болгож, ар хударгаар нь орж ууц руу нь мэс дүрлээ. Үүнийг хэзээ ч мартаж зүгээр өнгөрөөхгүй. Манай наадах ч гэсэн мөн таарч дээ! Түүний үхэл бол бас л өөрийг нь дайрсан хэрэг. Надя бас тэр хараал идсэн хотынх, тэнд өсөж бойжсон, мах цуснаасаа Петербургийн хүн, түүний бүх юм мань хүний эсрэг байсан, гэтэл эд нар нэрмэчихэж. Хэнд ч итгэх арга алга, тэр ч байтугай эхнэртээ итгэх ч арга алга. Тэд нар түүнийг ганцаардуулах гэж байна. За яахав! Мань хүн ганцаараа ч гэсэн тэднийг цөмөөрөнг нь дөнгөхтэй. Нөлөөлөх!.. Серго бас нөлөөлөх санаатай гэнэ... Түүн шиг хүнд нөлөөлөх юм гэнэ! Муусайн бардам тэнэгүүд!

Киров гэж нэг дутуу бойжсон дундаж сэхээтэн, хоосон цэцэрхэгч. Арван долдугаар их хурал дээр уриа хашгируулаад л байсан, Их хуралд зориулан Улаан талбайд хийсэн цуглаан дээр бас л уриа хашгирцагасан. Уул нь Москвагийнхны өмнө Ленинградын мужийн намын байгууллагыг төлөөлөн хэн нэгэн хүн биш, БҮХ намыг төлөөлсөн Улс төрийн Товчооны гишүүн хүн үг хэлэх ёстой байсан юм. Гэтэл тэр дургүйцсэнгүй. Тэгээд үг хэлсэн. Итгэл алга!

Кировыг Москвад шилжүүлэх хэрэгтэй. Энд нүдэнд ил байхын дээр хэн болох нь гарцаагүй тодорно. Ер нь ч хоёрдугаар нийслэлийг ингээд цэглэе.

Хэнийг явуулахаа мөн олов оо, Ваня Будягиныг явуулсан байж гэнэ! Ард ухаантай хүн олсонгүй. Рязановын тухай ганцхан асуулт асуугаад л түүнийг бариад авсан: “Пятаков тийш нь комисс явуулсан...” Шууд хариулахаас зайлсхийсэн хэрэг. Гэтэл Рязанов тэр комиссыг чухамдаа гэрийн хорионд байлгаж байгаад дараа нь Москва руу буцаачихсан шүү дээ. Тэд үүнийг яагаад түүнээс нууж байна вэ? Өөрсдийнхөө зөрчил маргааныг нууж, аппаратаа нэгдмэл цул байгаа гэж харуулах гэж байна. Рязановын тэнд хотын намын хорооны нарийн бичгийн дарга нь Ломиназе байгаа, бас түүний гүйцэтгэж байгаа үүргийг нуух гэж байна. Тэд

нарын алхам бүрийг санал бодол болгоныг нь мэдэж байгаа мань хүнээс нуух юм гэнэ.

Комиссыг баривчилж буцаана гэдэг бол онцгой явдал. Рязанов үүний учир хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ энэ явдал бол Оржоникизегийн хүрээлэлд ноцтой үйл явц болж байгааг бас гэрчилж байна. Хэдийгээр комиссыг Пятаков бүрдүүлсэн ч гэсэн энэ бол Оржоникизегийн нүүр рүү нулимсан хэрэг.

Тэд энэ зөрчилдөөнөө өөрснөө тэрүүхэндээ зохицуулахын тулд түүнээс нуухыг оролджээ. Эндүүрцгээж байгаа нь тэр. Тэрээр өөрөө учрыг нь олно.

Сталин цонхноос холдож харилцуураа аваад Рязановыг Москвад яаралтай дуудаж ирүүлэхийг Поскрёбышевг тушаав.

Рязанов дуудлага хүлээж байсан учир шийд дуулангуут тэр өдрөө гарав. Тэрээр энэ бүхэн юугаар дуусаж болохыг ойлгож байжээ. Ажлаас нь халаад намаас нь хөөчихнө. Үүнийг мэдсээр байж хийх юмаа хийсэн болохоор одоо хариуцлагыг нь хүлээхэд бэлэн байв.

Марк Александрович орон сууцны иж бүрэн барилга байгууламжаас гадна кино театр, Осоавиахимийн[9] клуб, пионерийн зуслан, хүүхдийн цэцэрлэг, “Уралын Мацеста” гэж нэрлэсэн хүхэрлэг халуун рашааны дэргэд эмчилгээний төв энэ тэрийг үнэхээр бариулж эхэлсэн юмсанж. Амьдралын хэвийн нөхцөлийг хангахгүйгээр үйлдвэрийг мэргэжилтэй ажиллах хучнээр байнга хангах боломжгүй юм. Улс оронд төмөр хэрэгтэй гэдгийг Марк Александрович хэнээс ч дутуугүй мэдэж байсан, тэгээд ч тэр төмрийг нь өгсөөр байлаа. Түүнээс гадна ганц төмрөөр бүх юм дуусаж байгаа биш гэдгийг мань хүн бас мэдэж байсан юм. Улс оронд аж үйлдвэр хэрэгтэй. Хэдхэн үйлдвэртэй Ази маягийн Орос биш, яагаад гэвэл ганц нэг үйлдвэрийг Конгод ч барьчихсан болно, харин хүнд үйлдвэржиж, европжсон социалист Оросыг байгуулах хэрэгтэй. Үүний тулд суурь машин дээр халыг мөлт ажиллахыг заалгасан хөдөөгийн харчуул биш, орчин үеийн иргэншлийн бүх ололтыг ашиглаж чадах соёл боловсрол сайтай боловсон ажилчин хэрэгтэй. Ахуйн соёл бол үйлдвэрлэлийн соёлын бүрэлдэхүүн хэсэг. Нүүр нүдгүй шуурган дунд нэг үйлдвэр барьчихаж болно. Харин тийм аргаар орчин үеийн аж үйлдвэрийг байгуулж болохгүй.

Дөнгөж ганцхан кино театр, ганцхан клуб, хүүхдийн цэцэрлэг, эмчилгээний ганцхан төв гэдэг бол тун өчүүхэн зүйл. Гэхдээ энэ бол зөвхөн эхлэл гэдгийг цөмөөрөө ойлгож байлаа. Хүмүүс тухайн үедээ домна, мартен зуухыг барих гэж бадрангүй сэтгэлээр зүтгэж байсан шигээ үдэш оройн цагаар ч, амралтынхаа өдөр ч хүч хайргүй ажиллана. Гэтэл Рязановыг төлөвлөгөөнөөс гадуур барилга барих ажил сэдсэн, хүмүүст ажлын хөлс өгөхгүй албадан ажиллуулж байгаа юм шиг Москва руу хов хүргэсэн ажээ.

Пятаков комисс ирүүлжээ. Тэр комиссыг тэргүүн зэргийн зорилт бол ширэм гэхээс өөр юм мэдэхгүй, хуучин томоохон хэрнээ явцуухан аж ахуйн зүтгэлтэн толгойлсон байв. Түр орон сууц гээд байхдаа яах вэ дээ! Иргэний дайны үед цасан дээр л унтацгааж явсан даг. Комиссын гол мэргэжилтнээр Бухарины үзлийг баримталдаг нэрд гарсан нэг эдийн засагчийг томилжээ. Тэрээр хориод оны үед Урал бол хэтийн төлөв муутай, нүүрс, нефть элбэгээс гадна түүний бат итгэж байгаачлан цахилгаанжуулалтын үндэс болох усны нөөц ихтэй учир аж үйлдвэрийг Сибирь рүү байгуулахаар баримжаалах хэрэгтэй гэж нотолж байсан хүн.

Энэ комисс Рязановын орон сууц, ахуйн программыг дэмжихгүй, үйлдвэрийг хөгжүүлэх төлөвийг үгүйсгэнэ гэдэг нь бүр эхнээсээ тодорхой байлаа. Тийм комиссыг үйлдвэртээ оруулж, тэд нарын бэлтгээд байгаа дүгнэлтийг хийлгэнэ гэдэг бол хамт олны урмыг хугална гэсэн үг.

Рязановын тушаалаар тэр эрхэм хүндэт комиссыг Хотын гаднах байшинд оруулжээ. Засгийн газрын гишүүдэд зориулсан, үйлдвэрээс хориод километр зайтай сайхан байгальтай газар байдаг тусгай гал тогоотой, тусгай үйлчилгээтэй өргөөг тэгж нэрлэдэг аж. Комиссын гишүүд сэтгэл дүүрэн байцгаажээ. Гэтэл тэдэнд машин ирүүлсэнгүй учир үйлдвэр хүртэл хөл

дүүжлэх юм байдаггүй нэгэн гачлан гарчээ. Тэднийг өдөрт гурван удаа муугүй хооллодог боловч утсаар Москвагаар ч яриулдаггүй, Рязановтой ч яриулдаггүй гэнэ. Эхний өдөр тэд цадтал хоол унд идэж, машин ирүүлж чадаагүй Рязановыг дооглож байсан бол хоёр дахь өдрөө дургүйцэн уурлаж, гурав дахь өдөр нь болоход залилуулаад байгаагаар ойлгоцгоожээ. Дөрөв дэх өдөр нь тэднийг шаардсан ёсоор нь галт тэрэгний буудалд хүргэж, томилолтыг нь бөглөж өгөөд зөөлөн суудлын билет гардуулаад Москва руу буцаажээ. Марк Александрович энэ үйлдлийг Ломиназед хэлэлгүй хийжээ. Сталин түүнд муу болохоор түүнийг оролцуулбал ажилд гагцхүү хор хургэхээс өөр юм байхгүй.

Арван долдугаар их хурлаас хойш Рязанов, Ломиназе хоёрын харилцаа төвөгтэй болжээ. Ломиназег Төв Хорооны бүрэлдэхүүнээс гаргаж, Рязановыг оруулсан учир тэрээр Ломиназетэй жишихэд улс төрийн хувьд дээгүүр байр суурьтай болсон байна. Марк Александрович инженер хүн. Ломиназе хэдий ухаантай, авьяастай хүн боловч техник мэдэхгүй. Энэ бүхний нэмэрт үйлдвэрийн дарга намд шинэ хүн биш олонхи цех, хэлтэс, ээлжийн дарга нар коммунистууд билээ. Тэд нар иргэний дайны үеийн цэргийн мэргэжилтнүүд биш болохоор тэдэнд комиссарын хэрэг байхгүй.

Яралзтал үг хэлж, түүхийн жишээ иш татах энэ тэр бол сайхан хэрэг! Гэхдээ өөр цагт, өөр газар, өөр нэгэн учралаар ингэж байхад болохсон! Марк Александрович гурван жил Америкт суусан, Европыг хөндлөн гудас хэсчихсэн болохоор хичнээн алдаж хоцорчихоод байгааг мэднэ. Тэгэхлээр ажлаа явуулж, хөөж гүйцэх хэрэгтэй, үүнээс бусад юу ч байсан чалчаа хоосон үг. Коммунизмын тухай бясалган хэлэлцэх биш, түүнийг барих хэрэгтэй гэж үздэг билээ.

Ломиназе урьдын адил нөлөөтэй байгаасан бол түүнийг оролцуулахад хэрэг бололгүй яахав. Гэвч төвд ч гэсэн, мужид ч гэсэн, энэ хотдоо ч гэсэн Рязановын үг илүү жинтэй байгаа билээ. Ломиназе Оржоникизегийн хайрыг хүлээсэн, түүнтэй ярьдаг шууд утастай хүн гэдэг нь үнэн, гэхдээ үйлдвэрт хэрэгтэй бүх юмыг Рязанов өөрөө Оржоникизегээс авч чадна. Түүнээс гадна аар саархан юм болгоны төлөө Серго руу яваад байлтай нь биш, бүх асуудлыг аппарат л шийднэ шүү дээ, аппарат бол гагцхүү Рязановыг л мэднэ. Үйлдвэр гэдэг маань Рязановын амь бие, амьдрал, үхэл.

Марк Александрович комиссыг аргалах тухайгаа сайтар эргэцуулэн бодсон бөгөөд тун эгзэгтэй хэрэг хийж байна гэдгээ бүрэн ойлгож байжээ. Харин аз таарсан нөхцөлд маш том юм хожиж, түүний байр суурь цаашид урт хугацаанд бэхжиж өгнө. Пятаков Оржоникизегийн зөвшөөрөлгүйгээр тэр комиссыг явуулсан учраас мань хүн өөрийг нь дэмжинэ гэж Рязанов тооцоолжээ. Түүнээс гадна энэ явдалд Ломиназег хутгалдуулаагүйг Серго бас үнэлнэ. Марк бас Ворошилов түүнийг дэмжинэ гэж горьдож байв.

Тэрээр сарын өмнө Алс Дорнодоос буцахдаа үүгээр орж, бүх юманд сэтгэл ханаж Марк Александровичийн мөр лүү нөхөрсгөөр алгадаж,

–Би большевик хоншоортой хүн, төмрийн үнэр мэдэгдээд байна гэж байсан билээ.

Сталин өөрийнх нь оронд байсан бол яг л ингэх байсан учраас тэрээр өөрийг нь ойлгоно гэж Рязанов найджээ. Чухамдаа тийнхүү шийдэхэд гол зүйл энэ байжээ. Рязанов бол Сталины

хүн, түүний үйлдвэр, түүний Уралыг төлөөлж байгаа хүн. Сталин үүнийг үнэлэхгүй байх ёсгүй.

Асуудлыг Кремльд Сталин, Ворошилов, Оржоникизе, Төв Хорооны зохион байгуулалт - хуваарилалтын хэлтсийн шинэ эрхлэгч Ежов гэдэг цэнхэр нүдтэй эелдэг даруухан хүн дөрвүүлээ хэлэлцэв.

Марк Александрович учрыг тайлбарлав. Тэрээр хэнийг ч баривчлаагүй. Комиссын гишүүд дуртай зүгтээ явах бололцоотой байсан. Харин нөхөр Оржоникизетэй ярилцталаа тэднийг үйлдвэрт ирүүлэхийг саатуулсан, энэ комисс үйлдвэрт ирэхийг хортой зүйл гэж үзсэн учраас түүнийг Москва руу буцаахыг нөхөр Оржоникизегээс гуйх гэсэн юм. Тэгээд Москва руу утасдсан чинь Серго өмнө зүгт яваа, хэд хоногийн дараа ирнэ гэж хэлсэн. Тэр комисс хэдэн өдөр хүлээвэл болох байсан, ямар шатчих гээд байсан биш. Ахуйн барилга байгууламжийн тухайд гэвэл батлагдсан төсөвт хөрөнгөний хэмжээнд ажилчдын сайн дурын оролцоогоор хийгдэж байгаа ажил. Үүнийг шалгахын тулд ийм эрхэм хүндтэй комисс биш, зүгээр л хяналтын нягтлан бодогч ирүүлэхэд хангалттай байсан юм.

Түүний үгийг таслалгүй, чимээгүй сонсоцгоов. Сталин гаансаа барин өрөөн дундуур холхиж, Оржоникизе хөмсөг зангидан сууна. Ежов дэлгээтэй том тэмдэглэлийн дэвтэр бариад ширээ өнцөгдөсхийн даруухан сууна. Ворошилов урам оруулж инээмсэглэснээ Рязанов комиссыг эрхэм хүндтэй гэж хэлмэгц инээд алджээ. Тэгээд хамгийн түрүүнд үг хэлэв.

–Би саяхан эдний үйлдвэрээр дайрсан. Үйлдвэрийн ажил сайн, металлаа ёсоор нь гаргаж, хамт олон эв нэгдэлтэй, удирдлага нь нэр хүндтэй байна лээ. Тэнд комбинат байгуулахыг эсэргүүцэж байсан профессорыг тийш нь яах гэж явуулсан юм бол? Рязановын үйлдлийг буруушаахаар юм алга, зүйтэй шийдсэн байна. Тэрээр нөхөр Сергог хүлээсэн байна, тэгэхлээр комисс ч хүлээх л ёстой байж. Хүлээхгүй гэж л дээ. Тэгвэл яах вэ дээ, тэдний дур юм чинь. Түүнээс гадна нөхөр Рязанов бас зөв юм ярилаа. Бид ганцхан байцаагч явуулаад болчих юман дээр комисс явуулах дуртай болчихоод байна. Нөхөр Рязановыг дэмжих хэрэгтэй.

Оржоникизегийн юу хэлэхийг бүгдээрээ хүлээцгээнэ. Тэрээр,

–Энэ ч тийм л дээ. Тийм гэж саная. Гэтэл нөхөр Рязанов, та комиссын гишүүдийг унаагаар тасалсан төдийгүй холбоогоор бас тасалсан байна. Та надтай ярих гэсэн байна, энэ бол таны эрх. Гэтэл тэд бас Москвагаар холбоо барих гэсэн байна, энэ бол тэдний эрх гэж өгүүлэв.

–Григорий Константинович, танд буруу мэдээ өгсөн байна хэмээн Рязанов зөрж,

–Манай Москвагаар ярьдаг холбоо базаахгүй ажилладаг, энэ бол мэдэгдэж байгаа зүйл. Тэгэхлээр Москвагаар ердийн журмаар холбоо барина гэж хэрэг дээрээ байхгүй. Харин Григорий Константинович, тантай ярьдаг шууд утас манайд хоёр бий, нэг нь минийх, нөгөө нь нөхөр Ломиназегийнх. Тэд нөхөр Ломиназед хүсэлт тавиагүй, ер нь ч тэр энэ хэрэгт огт оролцоогүй юм, миний хувьд гэвэл би тэдэнд аппаратаа өгөх боломжгүй гэж үзсэн юм. Өгсөн бол тэд нар Пятаковтай холбоо бариад цаадах нь комиссын захирах эрхийг батлах л байсан биз. Харин би таныг батлахгүй гэж тооцоод хүлээж байсан юм, яг үнэнээ л хэлж байна гэв.

Ломиназе, Серго хоёрын шууд утасны тухай дурсахад Сталины нуруу татвасхийснийг Марк Александрович анзаарав.

Сталин сэтгэл нь хөдөлсөн бололтой тод гүрж аялгаар үг бүрээ зугуухан зөөж шууд хэлэх юмандаа оров.

–Уралыг тоодоггүй хүнийг бид Уралд байлгахын хэрэггүй. Уралыг тоодоггүй хүмүүс Москвад өөрийнхөө сандал дээр сууж байна биз. Тийм комисс явуулна гэдэг бол бүдүүлэг алдаа. Энэ талаар нөхөр Пятаковт зааж анхааруулах хэрэгтэй.

Тэрээр түр чимээгүй болов. Ежов тэмдэглэлийнхээ дэвтэрт түргэн бичиж авч байна.

–Орон сууцны болон ахуйн барилгыг зохих хэмжээгээр барих явдал ялангуяа үйлдвэрлэлийн даалгаврыг амжилттай хэрэгжүүлж байгаа газар зайлшгүй хэрэгтэй. Ажилчин анги социализмын бодит ололтыг харах ёстой. Зөвхөн цалин ч биш, хөрөнгөтнүүд ч цалин олгодог юм чинь. Ажилчин ангид социализмын үр дүнг сувиллын газар, хүүхдийн цэцэрлэг, чухамхүү тэдний хүүхдэд, ажилчдын хүүхдэд зориулсан хүүхдийн цэцэрлэг зэрэг соёл, ахуйн газруудаар үзүүлэх хэрэгтэй. Комбинатын ажилчид төлөвлөгөөгөө биелүүлж байгаа учраас тэд тийм зүйлтэй байх эрхтэй. Хүний төлөө санаа тавина гэдэг бол ерөөсөө л энэ шүү дээ. Бодитой юу? Бодитой. Үзэгдэхүйц үү? Үзэгдэхүйц. Үнэмшилтэй юу? Үнэмшилтэй.

Сталин гаансандаа тамхи дүүргээд ингэж асуув.

–Энэ зөрчилдөөнд хотын намын хороо ямар үүрэгтэй байв? Ямар үүрэгтэй байсныг би харахгүй байна. Ер нь намын хороо хаа байгаа юм бэ? Яагаад үйлдвэрийн дарга комисс ирсэн тухай хотын намын хороонд мэдэгдсэнгүй вэ? Яагаад тоогоогүй байна?

Рязанов хариулах гэж оролдсон боловч Сталин гар дохин түүнийг болиулаад өөрөө үргэлжлүүлэн ярив.

–Нэр хүндгүй хэрэг үү? Яагаад нэр хүндгүй байна? Хэрэв нөхөр Ломиназе үйлдвэрийн ажлаар хөөцөлдөггүй юм бол ер нь юу хийж байдаг юм бэ? гэсэн асуулт гарч байна. Тэр чинь идэвхтэй хүн, зүгээр сууж чадахгүй. Дэлхий дахины асуудлаар хөөцөлдөж байгаа хэрэг үү? Яагаад яг өөрийнхөө үүргийг биелүүлэхгүй байна вэ? Намын байгууллагууд яг шууд үүргээ биелүүлэхгүй байгаа газарт аж ахуйн хүмүүс ө ө р нөхцөл байдалд бол өөрсдийгөө буруу хэрэгт оруулж мэдэх алхам хийхэд хүрч байна. Хотын намын хорооны нарийн бичгийн дарга яагаад ардын комиссартай шууд утастай байна? Тэр чинь мужийн намын хорооны нарийн бичгийн даргатай л шууд утастай байх ёстой шүү дээ.

–Шууд утас ч юу шалих вэ дээ гэж Оржоникизе ярвайсхийв.

–Яль бүл зүйл хэмээн Сталин зөвшөөрснөө гэнэтхэн сайхан инээмсэглэж,

–Гэхдээ л ажилд нь саад болоод байгаа. Бусад хотын намын хорооны нарийн бичгийн дарга нар чамтай шууд утасгүй шүү дээ, гэсэн ч болоод л байна. Манай хүндэт нөхөр Ломиназег онцгой байдалтай байлгах хэрэг юу билээ? Энэ бол намын залуу удирдагч Ломиназегийн

хувьд хүмүүжлийн муу уршиг тарина. Энэ бол өөрийнх нь тухай түүнд хуурамч төсөөлөл төрүүлнэ. Бид ингэснээрээ нөхөр Ломиназед тус биш ус болж байна гэв.

Марк Александрович Сталины тухайд эндүүрсэнгүй. Сталин ч бас түүний тухайд эндүүрсэнгүй. Тэр хоёр дотуураа ийнхүү ойртон дотносож, энэ нь Марк Александровичийг тэртээ дээш нь хөөргөлөө. Тэднийг тусгаарлаж байсан хүмүүс, албан байгууллага, бичиг цаас бүгд хийсэн арилж ач холбогдлоо алдсан мэт болов. Одоо ингээд Марк Александровичийг ганцхан Сталин удирдана. Тэрээр сэтгэл дотроо түүнтэй зөвлөж, хэрэг явдлаа түүний хэмжүүрээр хэмжиж үнэлдэг болов.

Ингэж бодохоос Марк Александрович өөрийнхөө хүч чадал, учир холбогдлоор бахархах сэтгэл бялхана. Хэзээний эзэрхэг зантай болохоор одоо захирах янзаа бүр нуухаа больжээ. Тэрээр амьдрах төрх байдал, дадал заншлаа огтхон ч өөрчлөөгүй. Ардын комиссартай уулзахын өмнө хэлтэс, тасгуудаар орж жирийн ажилтан нартай ярилцана. Цаадуул нь түүний асуудлыг урьдын адил дуртайяа авч үзэж, үйлдвэрийн эрх ашигт нийцүүлэн, өөрөөр хэлбэл Марк Александровичийн хүссэнчлэн шийдэж өгсөөр байна. Тэгээд ч Рязанов илт захирах янзтай болсон түүний тэр нэгэн шинэ байдлыг хэн ч анзаараагүй ажээ. Хуучин мань хүн ажилтны ширээ рүү очиж суугаад ярилцдаг байсан бол одоо зогсоогоороо ярилцаж цаадуул нь босдог болжээ. Уриалгахан, найр тавьсан аятайхан яриа болдог ч гэсэн явдал дундын яриа. Алдартай үйлдвэрийн алдартай дарга, бас Сталин, Оржоникизе нарын хайртай хүн төдийгүй хожмын тэдний ардын комиссар нь байж болох хүн ингэж ярилцаж байгаа тул ингэх нь зүй ёсны мэт санагдана. Тийм хүн хэрнээсээ бардамнаж сагсуурахгүй урьдын адил аппаратын жирийн ажилтан нар дээр орж гарч байна шүү дээ. Марк Александрович, Оржоникизе хоёрын дунд нэг яльгүй ярвигтай байдал үүслээ. Сталины тэнд болсон зөвлөлгөөн дээр Оржоникизе Сталин, Ворошилов хоёрыг эсэргүүцээгүй. Гэхдээ мань хүн бол Рязанов арай учиртайхан хандаж, Ардын комиссарын газрын нэрийг хорлосон тэр хэрүүл маргааныг гаргахгүй байж болох байсан гэж үзэж байжээ.

Серго сэтгэл гонсгор байгааг Марк Александрович шууд мэдэж үүнд гутарсан боловч Оржоникизе өшөө өвөрлөж муу юм санадаггүйг мэднэ. Тэгэх тусмаа тэр асуудлаар чухамдаа Марк Александровичийн зөв байсан, бас Ломиназегийн талаарх Сталин тэр хоёрын зөрөөний буруутан мань хүн биш юм чинь.

Оржоникизе өөрөө дуудахыг нь хүлээсхийн Марк Александрович түүн рүү очихоо азнаж, одоо хэр аппаратын хүмүүстэй уулзаж, Улсын төлөвлөгөөний хороо, Улсын банк энэ тэрээр орж ажил явдлаа амжуулж байв. Москвад ирэх тоолондоо, тэр ч байтугай засгийн газрын яаралтай дуудлагаар ирсэн ч гэсэн гагцхүү энд л шийдэж болох өдий төдий асуудалтай ирдэг билээ. Будягин хэдийгээр Ардын комиссарын газар ажиллах хоногийнх нь тоо гүйцэж байгаа ч гэсэн бас түүнтэй орж уулзах ёстой. Марк Александрович түүнийг Ломиназегээс илүү өрөвдөж байгаа юм. Будягин онолч буюу уран илтгэгч биш, харин ажилтан хүн, хэдийгээр инженер биш ч гэсэн ажил явдлын учрыг дор нь ойлгоно. Гэвч тэрээр замаас гарчихсан, цаг хугацаа түүнээс түрүүлчихсэн байна, одооны цаг хугацаа бол Сталин, гэтэл мань хүн Сталинд дургүй, түүний эсрэг зогсож байна, тэгэхлээр улс орны эсрэг, намын эсрэг зогсож байгаа гэсэн үг.

Марк Александрович Будягинтай даргынх нь хувьд, ардын комиссарын орлогчийнх нь хувьд

тайван, ажил хэрэгчээр ярилцаж байснаа Оржоникизегийн орлогчоор Пятаков, Будягин хоёрыг яагаад тавьсан юм бол? гэж гэнэтхэн бодов. Сергогийн эргэн тойронд Сталинд үнэнч эсэх нь эргэлзээтэй олон хүн байна. Серго ийм туслахуудыг өөрөө сонгож авав уу, эсвэл түүнд томилж өгсөн болов уу? Ямар зорилгоор тэр вэ? Будягин ч гэсэн Рязановтой тогтуухан ярилцав. Тэр ч байтугай комиссын тухай ч асуусангүй. Харин гарын үсэг зурж, ажил явдлаа дуусгасны дараа өөр нэг юм асуув.

–Зээ чинь юу болж байна?

Марк Александрович ийм асуулт тавина гэж санасангүй. Орой нь эгч рүүгээ очно гэж бодож байсан боловч тэр оройгоо явахаас өөр үггүй болжээ.

–Одоохондоо сууж л байгаа...

Будягин өөр юу ч асуусангүй, Марк Александрович ч тэдний өрөөнөөс гарлаа. Гэтэл сэтгэлд нэг л эвгүй сэв суучихав. Саша баригдсан гэдгийг Будягин өөрөө мэдэж байгаа. Тэрээр өөр зүйл асуусан юм. Сталинтай уулзсанаа ашиглаж Сашагийн тухай гуйв уу, үгүй юу? гэж л асуусан хэрэг. Хүн доромжилсон асуулт.

Барьж байх үндэстэй учраас тэнд байлгаад байгаа тэр нэг бандийн төлөө ТҮҮНИЙ цагаас үрж байх эрх мань хүнд бий билүү? Баахан тэнэглэсэн гэдэг нь эргэлзээ алга. Марк Александровичийн Березинд тавьсан хүсэлт талаар өнгөрөх ёсгүй, гэтэл Саша тэндээ байсаар л байна. Тэгэхлээр ямар нэг хэрэг тарьж л дээ.

Ийм нөхцөл байдалд би яаж Сталинд яаж хүсэлт тавих юм бэ? Сталин зээ нь баривчлагдсаныг эс харгалзан түүнийг Төв Хорооны бүрэлдэхүүнд оруулсан. Сталин түүнийг Сашагаас салган авч үзэж, тэр асуудлыг хэрэгсээгүй байна. Одоо тэр асуудлыг өөрөө Сталинд тавих хэрэг үү? Ёс алдсан болно! Сталин яг л тэгж үнэлнэ. Тэгэх юм бол тэр хоёрын дотоод ойртолт, харилцан ойлгож байгаа байдал эвдэрнэ. Байдал ийм л байна. Гэтэл Будягин түүнийг энэ тухай Сталинтай ярихаасаа ердөө л хулчийсан гэж үзэж байна. “Улс төрийн хувьд мөхөж гүйцсэн болхи амьтан” гэж Будягины тухай Марк Александрович дургүйцэн бодов.

Ханын хоёр талаас яаж тогшилцдогийг Савелий Сашад үзүүлжээ. Цагаан толгойг тав таван үсэгтэй зургаан эгнээнд хуваадаг гэнэ. Эхний тогшилт эгнээг, хоёр дахь нь эгнээн доторх үсгийн байршлыг заана. Тогшилтуудын хооронд богинохон завсар байвал тэр нь эгнээ, үсэгнүүдийн хоорондох зай арай удаан, үгнүүдийн хоорондох зай түүнээс илүү удаан байх ёстой, ханан дээгүүр зурах нь “дууслаа!”, эсвэл “зогс!”, эсвэл “давт!” гэсэн дохио аж. Тэр зай завсар нь маш богинохон, туршлагатай хоригдлуудын хувьд секундын хэдэн хувь байдаг ажээ. Тэр зай л хамгийн төвөгтэй, хэрэв түүнийг л ялгаж сонсож чадахгүй бол авиа хоорондоо нийлж, өөр үсэг болоод утга нь алдарчихна.

Саша тамхины хайрцгийн картон дээр тулэнхий шүдэнзээр цагаан толгойг бичиж байгаад тогшилцож эхэллээ. Тэрээр хянагч сонсох вий хэмээн орон дээрээ хэвтэж хөнжлөө нөмөрч байгаад сайн сураагүй болохоор хооронд нь их зайтай удаан гэгч нь тогшино. Хөрш нь түүнийг ойлгож байвч мань эр цаадах нь хоорондоо илт зайтай тов тодорхой тогшсоор байтал түүнийг сайн ойлгохгүй, үсгээ будилуулж, дахин давтан тогшуулна. Сашагийн овгийг асуугаад өөрийгөө намын гишүүн Чернявский гэв. Саша сонин авдаг эсэхийг асуугаад өөрөө бас авдаггүйгээ мэдэгдэв.

Гэхдээ цаадах нь нөгөө хөршөөсөө мэдэж авсан юм уу, элдэв юм мэдэж байв. Намын их хурал болсон, түүн дээр ямар нэгэн онцгой явдал болоогүй гэнэ. Тэрээр орой бүр Сашад сонин дуулгадаг боллоо. Хэрэв Сашагийн юм уу, эсвэл түүний өрөө рүү хянагч ойртож ирвэл тогшилцохоо больж, дараа нь дахиад шинээр эхлэх хэрэгтэй болдог байв. Мөсөнд няц цохиулсан “Челюскин” гэдэг хөлөг онгоц Хойт мөсөн далайд живсэн тухай мэдээлэхэд хоёр орой зарцуулж, дараагийн хоёр орой нь Францад фашизмыг эсэргүүцсэн бүх нийтийн ажил хаялт зарласан тухай мэдээлэв.

Ингэж байж чангаланд орж мэдэх боловч түүнийг эс хайхран, ганцаардлын зовлонг нь хуваалцан мэдээ тогшиж байгаа тэр хүнийг Саша яахин эс талархах билээ. Улс оронд бүтээн байгуулах ажил үйлс ундарч байхад мань хүн шоронгийн ганц хүний өрөөнд хоригдчихоод, зөвлөлтийн сонин хэвлэлд бичээд байгаа ердийн үйл явдлуудын тухай сонирхож байгааг нь хянагч мэдчих вий, ээ бурхан минь хэмээн үүд рүүгээ хулмалзан хялалзаж байх ч гэж дээ.

Хувь заяа ийм болсныг хүлцэн тэвчиж, зайлшгүй болсон энэ байдалтай эвлэрэх тэвчээр нь барагдаж байна. Үгүй ээ! Ийм хувь заяаг хэрхэвч хүлээж авахгүй. Эвлэрэхийг хүсэхгүй байна, хүсэхгүй, үгүй, үгүй... Энэ замыг хүсэхгүй, түүний зам бол намтайгаа, ард түмэнтэйгээ, улс оронтойгоо хамт байх зам. Яах вэ? Хэнд бичих вэ? Прокурорт уу? Прокурор баривчлах зөвшөөрөл өгсөн шүү дээ. Сталинд бичих үү? Түүний захидал Дьяковоос цааш явахгүй. Тэгээд ч юун тухай гомдол мэдүүлэхсэн билээ дээ? Маркийн хэрэгт холбогдолгүй гэж бичих үү? Гэтэл чухам ямар хэрэг байгааг мань хүн өөрөө мэдэхгүй, бас тэр хэргийн учир баригдсан эсэхээ ч мэдэхгүй шүү дээ.

Ингэж байтал Сашад нэг төлөвлөгөө боловсорч ирлээ. Бүтэлгүй зүйл, гэхдээ үзээд алдахад яахав.

Саша орой нь хөршгэйгөө тогшилцож байхдаа Маркийн толгойлж байсан барилга байгууламжийн тухай юу бичиж байдгийг асуугаад “Мэдээд хэлье” гэдэг хариу авлаа. Маргааш нь “Домна зуухаа асааж, одонгоо авцгаажээ” гэж мэдэгдэв. Саша “Рязанов?” гэж асуув. Хөрш нь “Лениний одон” гэж хариулав.

Марк хуучнаараа барилга байгууламжийнхаа даргыг хийгээд эрх чөлөөтэй явж байх нь!.. Тэгэхээр түүнтэй холбогдолгүй юм байна. Толгойд нь яаж тийм юм орж ирээ вэ? Сургуультай л холбоотой болж таарах нь.

Гэхдээ ханын сонинтой холбоотой биш, нөгөө үзүүрээсээ буюу Криворучкотой холбоотой байх нь. Районы намын хороон дээр ч тийш нь л чангаагаад байсан. Баулин, Лозгачёв хоёртой сүүлчийн удаа ярьсан зүйл яг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн байна. Тэрээр үүнийг тэр үедээ ойлгож, алдаа хийснээ тэр үедээ л мэдсэн, одоо тэр алдааныхаа шимийг хүртэж байна.

Бас Дьяков ч Криворучкогийн тухай их шургуу асуугаад байсан. “Тантай хэн хувьсгалын эсэргүү юм ярьсан бэ?”. Бүх юм тэндээс эхэлсэн байх нь! Аягүй бол Криворучко бас баригдчихаад, наанадаж хэлэхэд Саша өөрөөс нь өрсчихөж магадгүй гэж айхдаа Сталины тухай Сашатай ярьж байсан гэдгээ хүлээчихсэн байгаа байх. Тэгвэл Криворучко өөрөө үнэнээ хэлсэн шударга хүн, харин мань Саша бол түүнийг хаацайлсан шударга биш хүн болох нь... “Тантай хэн хувьсгалын эсэргүү юм ярьсан бэ?”

Мань хүн шударга биш зан гаргаж, өөрөө бүх юмаа тавиад туучихлаа, өөрөө өөртөө лай ланчиг хураалаа, Дьяковын зөв байжээ. Түүнийг даруй гурван долоо хоног дуудсангүй, магадгүй огт дуудахгүй байж ч мэднэ, баримтыг эсэргүүцээд ярдаглаад байгаа юм чинь дуудахын хэрэг юу байна. Аягүй бол хэргийг нь дуусгаад шийдчихсэн байх. Тэрээр өөрийнхөө буруугаар бүх юмаа нэгэнт алдсаныг ухамсарлаж, хэзээ хүрч ирж ямар ял заасныг мэдэгдэхийг хүлээн, хонгилын хөлийн чимээг чагнан өрөөн дотроо холхино. Шийдвэр хараахан гараагүй байлаа ч гэсэн Дьяков түүнийг дахин нэг дуудлаа ч гэсэн одоо үнэнээ хэлнэ гэхэд нэгэнт оройтжээ. Анхны байцаалт дээр бүх үнэнээ хэлсэн бол тэр нь сайн дураараа үнэнч шударгаар хэргээ хүлээсэн гэж үнэлэгдэх байсан. Одоо бол арга буюу хүлээсэн гэх буюу чин санаанаасаа биш, шударга биш гэж харагдана.

Өглөөд босох гэхээс дургүй хүрнэ, өдөр орой жорлонд аваачихыг хүлээх гэхээс дургүй нь хүрнэ. Тэгээд мань хүн Савелий шиг хөтөвч хувинг ашигладаг болов. Бас шөнийн цагаар шүршүүрт орох гэж босох гэхээс дургүй нь хүрэх тул нэг, хоёр удаа татгалзаж, сүүлдээ нөгөө харгалзагч түүн рүү ирэхээ больжээ. Гагцхүү юм л идээд баймаар санагдаж, хоол түгээгчдийг тэсэж ядан хүлээхийн хамт гэрээсээ эргэлт харуулдаж, идэх юмны тухай мөрөөдөн цагаан талх, мах хоёроос өөр юу ч хэрэггүй гэж нөгөө нэг зурвас бичсэндээ харуусан байна. Одоо хиам байх юм бол ёстой нэг ам дүүрэн сайхан үмхэхсэн! Тэрээр үгүйдээ ингэх эрхтэй байх ёстой. Яаж ч аргалах гэж оролдсон амьдрал нь нэгэнт өнгөрчээ! Эсэргүүгийн им тамгыг угаагаад арилах биш.

Чернявский тогшлоо. Гэвч Саша хариу өгсөнгүй. Чернявский гэж хэн болохыг мэдэхгүй юм чинь яагаад түүнтэй заавал тогшилцож байх албатай билээ? Энд сууж байгаа хүмүүстэй өөрт нь нийтлэг юм юу байна? Тэрээр ямар ч гэм буруугүй шударга коммунистууд Марк, Будягин хоёрыг энд байгаа гэж бодсон. Энд Марк ч байхгүй, Будягин ч байхгүй, энд шударга

коммунист байхгүй, энд бол хэрэг хийсэн хүн л суудаг юм байна. Савелий ч хэрэг хийсэн, Чернявский ч хэрэг хийсэн. Саша өөрөө ч хэрэг хийсэн, Криворучког өрөвдөж, арчаагүй зан гаргасан, тэгээд тэрнийхээ шанг хүртэж байна. Тэрээр эвлэршгүй тов тодорхой байр суурьтай болж чадаагүй учраас Азизян болон ханын сонины талаар гаргасан алдаа нь, аугаа их Сталинд эргэлзсэний нэгэн адил огт санамсаргүй зүйл биш! Хөнгөмсөг, биеэ тоосон зантай учраас бүх юмны учрыг өөрийнхөө ухаанаар олно гэж бодсон, гэтэл түүнээс ухааны тамир арай илүү улс аль хэдийн учрыг олсон юм гэж бас байдаг байна.

Төмөр торны цаана байгаа булингартай шилний өөдсийг дөрөвдүгээр сарын наран нэвглэн байна. Жинхэнэ хавар цагийн анхны өдөр ирж нар хэрхэн баярлаж баясаж байгааг Саша таамаглав. Тэрээр ширээн дээр гарч цонхны нүдийг онгойлголоо. Уул нь зөвхөн салхинд гарахдаа л онгойлгох номтой юм. Тэгтэл ч тэр даруй хаалганы түгжээний төмөр чихэнд чийртэй хяхарч, хянагч үүдэн дээр зогсож байх нь тэр.

–Хаагаарай! Цонхноос холд! Чангаланд ормоор байна уу?

Саша цонхны нүдийг хаагаад ширээн дээрээсээ үсэрч буув.

–Агаар амьсгалмаар байна.

Гэвч мань хүн гудамжны холын чимээ, трамвайны хонх, автомашины дохио, хүүхдийн дуу хоолой энэ тэрийг ямар ч атугай сонсож амжжээ. Тэрээр явган замын хатаж байгаа гадаргууг төсөөлөн бодов. Охидууд хэдийн хөнгөн хувцсандаа орчихсон, хүзүү хоолой, цэх шулуухан гар хөл нь ил явцгааж байгаа. Түүнийг энэ бүхнээс үнэхээр салгах юм гэж үү? Одоо ийнхүү эрүүл чийрэг, идэр залуу байхад... Тэр ярихгүй ээ! Тэрээр тэнд, хаврын тэр гудамжинд байх хүсэлтэй байна, бусдын адил зүгээр аж төрөх хүсэлтэй байна.

Ноднин жилийн яг ийм хавар цагаар мань эр авто бааз дээр практик хийсэн билээ. Гараашийн шилэн дээврийг төмрөөр нөхсөөр байгаад бараг шил гэх юм үлдээгүй тул дотор нь гэрэл гэгээ муутай, бензин, хярвас ханхална. Тэр бол Москвагийн Хөдөө аж ахуйн худалдаа гэж байхад тэр байгууллагын барьсан хамгийн хуучин гараашийн нэг бөгөөд тэнд талх зөөх зориулалттай “Форд-Т” гэдэг нэг тоннын даацтай машин хүртэл үлдсэн байдаг юм. Авто баазын дарга Антонов гэж нас залуу, хүрэн үстэй, нүдний шилтэй нэг хүн Сашад сайхан санагдсансан. Түүний хэрсүү ухаан, сэргэлэн авхаалж, өдөр шөнөгүй гараашаасаа салдаггүй энэ тэр нь сайхан санагддаг байсан. Хариуцлагатай ажилд дэвшүүлсэн энэ ажилчин бол хувьсгалаар төрсөн шинэ бүхний биелэл юм. Бүтээлч амьдрал руу хамгийн доод давхаргаас дуудагдсан хүмүүс, жинхэнэ ажилчны засаг, ард түмэн гэдэг тэр! Мань хүн ч гэсэн ард түмэнтэйгээ хамт байх ёстой, хуучин жолооч байсан Антонов, ачигч байсан Малов энэ тэртэй л хамт байх ёстой, түүний байх газар тэнд л байна, тэд нар бол дүвчигнэж цэцэрхэхгүй, хий ярьж шуугихгүй, зүгээр л ажлаа хийгээд бүтээн байгуулж байгаа улс. Энэ амьдрал хичнээн сайхан бэ, тэрээр үүнийг яасан дутуу үнэлж байж вэ. Гэхдээ ямар ч үнэ цэнэ төлдөг байсан хамаагүй, мань хүн тэр амьдралд эргэж ирэхдээ л нэг ирнэ!

Ном авчирч өглөө. Саша анх ном авчирч өгөхөд ихэд баярлаж байсан бол энэ удаа тэр номуудыг тоомсоргүй харав. Гиббоны гурав, дөрөвдүгээр боть, бас нэг хатуу хавтастай ноорхой ном байв. Тэр нь францын сенатч, жижиг хөрөнгөтний зүүний үзэлтэй зүтгэлтэн

Де-Монзи гэгчийн “ЗСБНХУ-аар явахад төрсөн сэтгэгдэл” гэдэг ном ажээ. Тэрээр хориод оны дундуур ЗСБНХУ-д ирсэн бөгөөд тэр тухайгаа өнгөцхөн ч гэсэн гүйлгээтэй ийм нэгэн ном бичжээ. Саша түүнийг захиалаагүй юм. Номын санч яах гэж ийм ном ирүүлэв?

Де-Монзи Зөвлөлт Холбоот Улсын тухай бүхэлдээ нааштай бичсэн боловч зарим нэг зүйлийг, ялангуяа эрүүгийн болон шүүхийн хууль тогтоомжийг шүүмжилсэн ажээ. Түүнийг нотлох гэж тавин наймдугаар зүйлийг иш татсан юмсанж. Чухам энэ зүйлээс болж номын санч энэ номыг ирүүлсэн байх нь. Сашагийн хүссэн эрүүгийн байцаан шийтгэх хуулийг номын санч ирүүлж яаж чадах вэ дээ.

Саша энэ зүйлээс ямар нэгэн чухал дорвитой юм олж мэдсэнгүй. Ер нь хэргийн учир тэр тавин наймдугаар зүйлд байгаа ч юм биш.

Шоронгийн танихгүй номын санч Сашагийн дуу хоолойг сонсож, гуйсан юмыг нь ойлгож, түүнд хүнлэг сайхан сэтгэл, аймшиггүй зориг, итгэл найдварын жишээг үзүүлсэнд л хэргийн учир байгаа юм.

Юунд хөтлөгдөж ингэв? Тэрээр албан үүргээ зөрчив үү? Тэгсэн байж магадгүй. Гэхдээ түүнээс илүү эрхэм үүрэг, хүнийхээ үүргийг биелүүлжээ. Хүмүүсийн тогтоосон хууль хүнлэг сэтгэлийн хуулинд харшлах ёсгүй. Буруугүй хүнийг шүүж, өмгөөлөлгүй хүнийг ивээлгүй орхиж, эрх мэдэлгүй хүний эцсийн эрхийг хасдаг хүмүүс л үүргээ зөрчиж байгаа юм.

Саша орон дээрээсээ босон харайсангүй, өрөөн дундуураа гүйж харайлгасангүй. Энэ болсон явдал түүнд байсан жинхэнэ хүнлэг чанартай юманд нь дүйсэн үнэхээр ариун тунгалаг зүйл байсан тул мань хүн цочирч догдолж сүйд майд болсонгүй. Тэрээр олох ёстой байсан юмаа л олсон хэрэг. Харин гагцхүү эр зоригоо гээсэндээ болж өөрөөсөө жигтэйхэн ичжээ.

Эцсийн байцаалт юунд хүргэхийг Саша мэдэж байсан болохоор айх ч юмгүй, горьдох ч юмгүй тийшээ очив. Сталин хурц хоол хийнэ гэж хэлснээрээ хүн хараахан дайсан болчихгүй. Дьяков үгийн шууд утгыг үл тоомсорлож, өөрийнхөөрөө тайлдаг учраас, Сашад энэ хэрэгт оролцох хүсэл алга. Тэрээр эндээс гарахыг л хүсэж байна. Гэхдээ намын ч өмнө, өөрийнхөө ч өмнө сэтгэлийн сэвгүй цэвэрхэн гарахыг хүсэж байна.

Дьяков түүнийг албархуу угтлаа.

–Сургуулийн явдлыг дуусгая, таны хүлээсэн зүйлүүдийг биччихсэн хэмээн тэрээр албархуу өгүүлж,

–Одоо та тэр бүхэндээ өөрөө улс төрийн үнэлэлт өгөх хэрэгтэй гэв.

–Ханын сонин гаргасныг би алдаа гэж хүлээж байна гэж Саша хариулав.

–Хувь хүний алдаа... хэмээн Дьяков тосгуулан авч,

–Гэтэл алдаа чинь бодит шалтгаантай, бодит үр дагавартай байдаг. Тийм шүү дээ? гэв. Тайллага эхэлж байгаа нь энэ. Дьяковын хувьд хүн гэдэг бол зөвхөн протокол бөглөхөд

зориулсан нэг нэгж, тэр протокол нь нөгөө хүнд ял онооход л хэрэгтэй зүйл.

–За Панкратов, ингэхлээр таны алдааны бодит шалтгаан, бодит үр дагавар юу байх вэ?

Саша Дьяковын хүүхэд царайг ажиглан харав. Түүнтэй Арбатад тааралдсан байх юм бол ч...

–Учрыг нь олно оо хэмээн Дьяков унзад дуугаар өгүүлж,

–Танай сургуульд улс төрийн эрүүл уур амьсгал байсан бол тийм ханын сонин гаргах бололцоогүй байх байсан. Гэтэл улс төрийн эрүүл уур амьсгал байсангүй. Криворучко намын эсрэг нууц байгууллагыг удирдаж байсан. Тэр нь одоо илэрч оролцогчдыг нь улайлгаж баривчилчихаад байна. Тэд нар манай энд байгаа, тэгээд хамаг хэргээ хүлээцгээсэн... гэв.

Иймэрхүү улс үйлдвэр дээр конторт шигдчихээд тоо бүртгэгчид, норм зохиогч хийх буюу боловсон хүчний хэлтэст юм хийсэн нэртэй байдагсан. Дьяков мань хүнийг ер яах вэ дээ? Тэрээр наян килограммын торхнуудыг үүрч чаддаг юм чинь, бас мод унагааж бэлдсэн ч газардахгүй. Бригадын дарга Аверкиев дээр юм уу, дивизийн захирагч байсан Морозов дээр буцаад очсон ч болно, тийм улс хаа л бол хаа байгаа, тэд бол жинхэнэ ард түмэн... Харин энэ мэтийн Дьяковчууд бол чухамдаа намын жинхэнэ дайснууд.

Дьяков саяынх нь хэлсэн зүйлийг сонсоод Саша мэл гайхна хэмээн горьдож бахаа хангах санаатай түүнийг хэсэг зуур харснаа үргэлжлүүлэн ярив.

–Панкратов, та туршлагагүй хүн юм, та тэдний занг мэдэхгүй байна. Криворучко оюутнуудын дургүйг хүргэхийн тулд нийтийн байрны барилгын ажлыг удаашруулж сунжруулж байсан, энэ бол оюутан олон тумнийг улс төрийн хувьд төөрөгдүүлэх гэсэн тактик. Ийм уур амьсгалд л Панкратов таны гаргасан шиг ханын сонин гарах бололцоотой болсон байна. Та хүссэн ч бай, эс хүссэн ч бай, Криворучко болон түүний балмад бүлгийнхний гарт өөрийн эрхгүй зэвсэг болж, тэд нар таныг хувьсгалын эсэргүү зорилгодоо ашигласан байна. Чухам ийм учраас л та энд байна шүү дээ. Та бас тэгээд өөрийнхөө алдааг улс төрийн талаас нь үнэлэхийг хүсэхгүй байгаа. Гэхдээ, Панкратов минь, түүнийг үнэлэхэд оройтоогүй байна. Бидэнд итгэж болно шүү.

“Бидэнд итгэж болно шүү...” Итгэх цагтаа итгэж явсан, одоо больё! Яг ийм үгэнд чинь итгэж явсан, ийм үг хичнээнийг сонссон билээ, өөрөө хичнээнийг ярьж явсан билээ. Энэ бол хүний үг биш, бөөгийн хараал. Лозгачёв, Азизян хоёр бөөлж байсан, Баулин бөөлж байсан, Столпер бөөлж байсан, одоо энэ Дьяков бөө бууж байна. Гэтэл энэ бөөгийн ширээн дээр гэм буруугүй хүмүүсийн амь нас дэнчигнэж байна. Дьяков Саша руу харав.

–Панкратов, та намайг ойлгов уу?

–Би таныг ойлголоо.

–За сайн байна, яг тэгээд биччихье.

–Гагцхүү үнэмшмээр л болгож үзээрэй хэмээн Саша Арбатын аль ч банди андуурч

ойлгохооргүй онцгой аясаар өгүүлэв. Гэтэл энэ мунаг толгойт юу ч ойлгосонгүй. Хүн айлгах чадвар, хүний хувь заяаг шийдэх эрхэндээ эрэмшин итгэж, азарган тахиа шиг ихэмсэг царайлчихаад эндшээ, яг энэ шорон дотор өөр шиг нь ийм дүрэмт хувцастай бусад нөхөд нь энэ бүхэн худал хуурмаг зүйл, бөөгийн наадам гэдгийг нүдээрээ үзэж, эрт орой алин боловч энэ бүхэн дуусна гэдгийг мэдээд амь насаараа дэнчин тавьж хүмүүст тус нэмэр болж байгааг огт мэдэхгүй байж байна.

–Тэгэлгүй дээ хэмээн Дьяков ихэмсэг хариулав. Дьяков Сашагийн хэргээ хүлээсний тэмдэглэлийн нооргийг урьдчилаад зэхчихсэн тул цаас руугаа шагайж, бэлэн маягтаа бөглөчихөөд нүдээр гүйлгэж уншсанаа дараа нь Сашад уншиж өгөв.

–Өөрийнхөө хийсэн хэрэг болон энд ямаршуухан зан байдалтай байснаа тунгаан бодохын хамт түүнд чин үнэн сэтгэлээсээ үнэлэлт өгөхийг эрмэлзэж, үүний өмнө өөрийн мэдүүлсэн зүйл дээр доорхийг нэмэн мэдүүлж байна: Октябрийн хувьсгалын арван зургаан жилийн ойгоор намын эсрэг ханын сонин гаргасан болон энэ ханын сониныг гаргах ажилд Руночкин, Ковалёв, Полужан, Позднякова нарын оюутныг татан оролцуулснаа миний улс төрийн алдаа гэж хүлээж байна. Криворучког өмгөөлж байснаа мөн миний улс төрийн алдаа гэж үзнэ. Эдгээр алдаа нь сургуулийн орлогч захирал Криворучкоогоос сургууль дээр бий болгосон улс төрийн байдлын үр дагавар болсон юм. Октябрийн хувьсгалын арван зургаан жилийн ойгоор ханын сонины намын эсрэг дугаар гаргасан явдал сургууль дээр Криворучкогийн явуулж байсан намын эсрэг чиг шугамын хэсэг мөн гэдгийг би хүлээн зөвшөөрч байна”.

Тэрээр сайхь хуудсаа Сашагийн урд тавилаа.

–Панкратов, би зөв бичиж үү, үгүй юу, шалгаарай тэгээд гарын үсгээ зурчих.

–Би ийм юманд хэзээ ч гарын үсэг зурахгүй гэж Саша Дьяковын нүд рүү эгцлэн харж өгүүлэв.

Арбатын амьдрал хуучин янзаар үргэлжилсээр. Дөрөвдүгээр сарын нар гэгээвчээр шагайж, бас гудамж замыг ээн булээцүүлнэ. Цэцэрлэгт гудамжны хунгарласан цас харлан доош сууж, сэрж буй газрын бүлээн амьсгал замын хучилтын завсар заалхайгаар уугин савсаж байна. Сургуулийн хүүхдүүд хөндлөн гудамнуудаар пальто, малгайгүй гүйлдэж, хөл бөмбөгөө элдэнэ. Байшин барилгыг тойруулан барьсан шат үзэгдэх болж түүн дээгүүр өрлөгчин, будагчингууд зэгдэн засах, будах, гүйцээж барих ажил хийж байна. Арбатын талбай дээрх хөдөлгөөнд саад болж байсан цөөхөн модтой бяцхан цэцэрлэг, хэдэн байшин энэ тэрийг буулгаж зайлуулжээ. Москва шинэ шинэ үйлдвэр, шинэ шинэ гацаа тосгоноор тэлэн өргөжиж, түр байшин сууцаар шавуулж байлаа.

Оройн цагаар Арбатад “Арбатский Арс”, “Карнавал”, “Прага”, “Художественный” кино театруудын гэрэл чимэглэл урьдын адил гялалзан яралзаж байна.

Пальтоныхоо захыг буулгаж эрээн алчуураа хүзүүндээ задгай орхиод, биеийн өнгөтэй нимгэн оймс татаж өндөр өсгийт өшиглөсөн Арбатын охидууд, бас Доргомиллов, Плющихийн охидууд явган замаар хөлхөлнө. Сашагийн байшингийн үүдээр мөн хэсэг багачуул холхин байна. Варя Улаан Армийн ордонд цэргийн сургуулиудын төгсөлтийн үдэшлэгт очих гэж яарч яваа тул тэдэн рүү нөхөрсгөөр гар даллаад дэргэдүүр нь өнгөрлөө. Варя ийм мундаг сүртэй үдэшлэгт хэзээ ч оролцож үзээгүй билээ. Тайзан дээрх тэргүүлэгчдийн байранд орон даяар нэр цууд гарсан цэргийн жанжнууд байна. Варя Будённыйг өөрөө таньсны гадна Серафимийн шивэгнэн нэрлэсэн хүмүүсийн дотроос насандаа үзээгүй гоё хүн болохоор нь Тухачевскийн нэрийг тогтоож авав. Варя хурал цуглаан, илтгэл тайланд дургүй ч гэсэн энэ үдэшлэгийн баяр ёслолын байдал, сүртэй сайхан танхим, цэргийн домогт дарга нарын төгсөгчиддөө бэлэгдэн ерөөж байгаа цэргийн гавьяаны сайхан зам, төгсөгчид нь ирээдүйгээ алдарт армийн командлагчаар төсөөлж, армийн командлагч нар нь залуу насаа идэрхэн төгсөгчидтэй зүйрлэн дарга, цэргийн ялгаа арилж эрчүүдийн, цэрэг эрсийн амь нэгссэн өөриймсөг уур амьсгал энэ тэрийг шохоорхон дур булаагдав. Цэргийн дарга нарын авгайчуул хүртэл онцгой янзын хүүхнүүд шиг санагдана. Тэд нар нөхрийнхөө мэргэжлийн аюул осол, зовлон зүдүүрийг хуваалцдаг улс. Энэ үдэшлэгт уригдсан бүсгүйчүүд ч гэсэн цэргийн албан хаагчдын тэр амьдралтай хэдийн нэгдэн нийлсэн мэт ёс төртэй байцгаана. Варя тэднийг год анхааралтай ажиглав. Зарим нэг нь маш гоё хувцасласан байх аж. Улаан армийн дуу бүжгийн чуулгыг Варя үүнээс өмнө төдийлөн сонирхдоггүй байсан бол өнөөдөр тэр нь сайхан санагдав. Цэргүүд сэтгэл гижигдсэн агсам сайхан жинхэнэ орос дуу, бүжгээ хэрхэн дуулж бүжиглэж байгаа нь үнэхээр сэтгэл татжээ.

Ордны амралтын танхимд үлээвэр хөгжимд фокстрот, румба, танго бүжгийн ая ямар ч жааз хөгжмийнхөөс дутахгүй сайхан эгшиглэж байна. Ийм байдалд энгүүн хөгжилтэй, сэргэлэн жавхаатай цэргийн сонсогчдын дэргэд өргөн шалбуур өмд, хурц эрээн зангиа, олигтой цэвэрлээгүй шаахайтай залуус тун эв хавгүй харагдах ажээ.

Нина ч бас өнөөдөр үглэж зовоохгүй, сайхан зантай шал өөр болчихсон байна. Гунигтай байхыг үзэхүл тэрээр Максимтай суухаасаа татгалзаад цаадах нь бүр явж байгаад харамссан хэрэг байх.

Серафим бас маргааш Алс Дорнод руу явна. Харин Варя бол энэ тухайд харамсахгүй байгаа. Учир юун гэвэл түүний авгай болохыг зөвшөөрч байгаагаа өнөөдрийн үдэшлэг дээр хэлсэн. Сургуулиа төгсгөөд түүн рүү очно. Үлдсэн энэ нэг жилд бол Серафим түүнд захиа бичиж, бүсгүй хариулж байх болно. Тэгэхлээр сургуулийн болон байрных нь бүх найз охид түүнийг Алс Дорнод руу нөхөр лүүгээ явна гэдгийг мэдэж авах юм. Түүний танил охидоос хэнийг нь ч Алс Дорнодод хүлээж байгаа хүн байхгүй учраас Варя дахиад л найз охидынхоо дундаас ялгараад явчихна. Тэрээр театр, кино, мөсөн гулгуур луу ганцаараа явж байна, бүжигт бол ерөөсөө явж байхгүй. Явж гэмээж нь Зоятой л бүжиглэнэ. Гэвч эр хүнтэй ч бас бүжиглэж болно л доо, гэхдээ тэдэнтэй огт танилцахгүй... Баярлалаа... Үгүй ээ, уучлаарай... Би чадахгүй л дээ... гэх жишээтэй. Хүний анхаарал татсан, Алс Дорнод руу явах гэж байгаа, хэн ч халдашгүй ганцаараа, ганц бие бүсгүй л байх юм. Сашагийн тухайд гэх юм бол Варя Софья Александровнаг зөнд нь орхихгүй, энэ бол Сашаг мөн орхихгүй гэсэн үг. Ингэхлээр Алс Дорнодод түүнийг Серафим хүсэн хүлээж, энд Москвад Софья Александровна, Саша хоёрт бас хэрэгтэйг бодохоос мань хүн өөрөө өөртөө улам сонин өвөрмөц санагдана.

Варяд хөгжилтэй сайхан байлаа. Серафим тэр хоёр сайхан бүжиглэж, цэргийн дээд дарга нар хүртэл авгайчуултай цуг тэднийг харуулдан байна. Варя Тухачевскийн зогсож байгаа булангийн тэнд аль болохоор удаан эргэлдэхийг хичээнэ.

Максим Нинатай бүжиглэнэ. Тэрээр сайхан зантай, шантгар хамартай малигар царай нь малилзан байна. Максимын нөхөд Нина руу очиж дараачийн бүжигт урихад мань хүн буланд зогсоод аанай л цагаан цайлган сэтгэлээр инээмсэглэн түүнийг хүлээнэ. Тэрээр ханхар цээжтэй, чац сайтайн хувьд яггүй тэнхээтэй болохоор олонхи тэнхээтэй хүний нэгэн адил хучээ ашиглахаас айж, хэн нэгнийг шүргэх, аль нэг юмыг гэмтээхээс болгоомжилж явдаг ажгуу.

Галч байсан эцэг нь ууж согтуурсаар байгаад архины цагаан солио тусаж үхэхэд лифтчин ээж нь дөрвөн хүүхэдтэй хоцорсон юмсанж. Максим хамгийн том нь байжээ. Багадаа ядуу зүдүү явсны харгайгаар юманд аригтай ханддаг зан сууж, сургуульд байхад нөхөд нь тэр занг нь харамчид тооцон, элдвээр нямбайлахад нь доог тохуу хийцгээдэг байжээ. Тэрээр самаа хулдаасан гэрэнд, цаасан тэмдэгтийг түрийвчинд, зоосон тэмдэгтийг хэтэвчинд, бал нь хугарчих вий гэж харандаагаа төмөр хошуувчинд хийж утасны дугаар, хаягтай тэмдэглэлийн дэвтрээ олон он жилээр хадгалж ирсэн бөгөөд эд юмны бөхөд, идэш уушны өегөд дуртай, гэхдээ хоолонд их мөнгө зарж сураагүй, өлсөх цангахдаа хүрвэл түүнээс буцдаггүй нэгэн билээ.

Хамгийн аж ахуйч сурагч хэмээн сургуульд байхад нь түүнд хамаг биет ажлыг өгдөг байжээ. Тэрээр протокол хөтөлнө, гишүүний татвар хураана, районы заавар бичгийг үдэж хавтаслана, тайлан гаргана. Юманд гүйх, мэдээлэх, зарлах, бичих, ухуулах хуудас наах, баяраар улаан даавуу олох, хамт олноороо театрт юм үзэх билет авах, дугуйлан, семинарт бүртгэж авах, санал хураахад тоо гаргах гэх бүх ажил Максимд л ноогдоно. Энэ бол үүнээс илүү юм хийж чадахгүй гэснийх биш юм. Зүгээр л ингээд сурчихсан, бүгдээрээ үүнд дасчихсан хэрэг.

Максим нөхдөөсөө нэг, аягүй бол хоёр нас ах байсан болохоор тэднийхээ маргааныг өчүүхэн зүйл гэж ойлгодог, тоглоом наадам болгож, бодь сэтгэл гарган цаадуулынхаа гайхшийг барна. Эр хүний гүйлгээ ухаан гаргаж элдэв муу юмыг тойрч сурсан, хэрэгтэй үед баашилж чаддаг ч

гэсэн итгэл үнэмшил болсон үзэл бодлоосоо хэзээ ч ухарч, нөхдөдөө тэрсэлж яваагүй. Насны эрхээр яваандаа цэрэг хүний энгийн хээгүй гэлтэй нугаршгүй бат нэгэн чанар хөгжин бэхжиж хоногшин үлджээ. Максим хугацаат цэргийн алба хаасныхаа дараа цэргийн дунд сургуульд орсон юм. Тэгснээр материаллаг хангамжтай болж амьдралаас залхаж гүйцсэн эмгэг хуучтай ээждээ, гэр орондоо тус нэмэр болж чадахтайгаа болжээ. Түүнээс гадна Максим дэг журамд дуртай. Улаан Армийн дарга гэдэг чинь идэр залуу, эрч хүчтэй, боловсрол, мэдлэгтэй хүмүүс гэж бодохоос цэргийн эрдэм түүнд сайхан санагджээ. Тэрээр цэргийн албанд, зөрчил буглан даамжирч байгаа хил дээр л байж байх ёстой. Хэдий ингэж санавч мань хүн Москвагаас явж байгаадаа гунигтай байв. Найз нөхдөөсөө, Нинагаас, Саша Панкратовоос, Лена Будягинаас, Вадим Марасевичээс салж одоход гунигтай байжээ. Энэ залуучууд бол өөрөө болон өөр шиг нь мянга мянган багачуул байшингийн чийгтэй харанхуй хонгилоос өндийн ирсэн тэр нэгэн аж амьдралын амьд биелэл билээ.

Максим жаахан байхдаа ээжийнхээ оронд заримдаа шат шүүрдэнэ. Нина түүнд тусална. Тэр нь Максимд хэцүү байснаас тэгсэн бус, энэ ажил бол аливаа бусад ажлын нэгэн адил хүнийг гутаахгүй гэдгийг байрны хүмүүст харуулах гэсэндээ тэгсэн хэрэг. Энэ бол комсомолын хүний үйлдэл, нөхөр ёсны дэмжлэгийн илрэл байсан юм.

Максим үүнээс шинэ ёс суртахууны учир утгыг аль ч номоос уншсанаас илүү ойлгосон билээ. Дараа нь, бүр есдүгээр ангид байхад нь нэг аймшигтай явдал болсон... “Московский комсомолец” гэдэг нисэх онгоц барих фондод цуглуулсан мөнгийг нь эцэг нь түүнээс хулгай хийгээд архидчихсан байжээ. Гучаад рубль гэдэг чинь тэр үедээ л бол яггүй их мөнгө. Максим гучин рубль хаанаас олох, нөхдийнхөө өмнө өөрийгөө яаж зөвтгөхөө мэдэхгүй тул амиа хорлох санаатай байжээ. Нина тэр байдлыг нь анзаарч, тулган шаардаж байж үнэнийг нь хэлүүлээд тэр даруй Сашад бүх зүйлийг ярьжээ. Саша түүнд,

–Ишш зайлуул, амь насаа яасан хямдхан үнэлдэг хүн бэ гэж хэлжээ.

Тэгээд ээжээсээ арван тавыг, Марк Александровичаас арван тавыг аваад Максимд тэр мөнгөө өгсөн юм. Тэрээр одоо тийм анд нөхдөөсөө салж байна. Саша түүнийг аварсан, гэтэл мань хүн Сашагаа хамгаалж байж чадсангүй...

Нина бүр арын хороонд цуг нуугдан тоглодог байх үеэс Максимд аятайхан санагддаг байжээ. Өсгөлөн товир биетэй, шийдэмгий зантай Нина сургуульд байхдаа бас л аятайхан санагддаг байсан. Түүний эв дүйгүй, зөрүүд, арчаа муутай байдал нь аятайхан санагдана. Бүсгүй өөрт нь хайргүй юм шиг байдагт мань эр итгэдэггүй. Цаадах нь өөрөө ч түүнийгээ мэдэхгүй юм чинь. Тэрээр Серафимийг тэднийд зориуд дагуулж очсон. Тэнэг биш, хөөрхөн, сайхан залуу юм чинь. Варя түүнтэй сууг гэж дагуулж очсон. Тэгэх юм бол Нинагийн Варяг хөл дээр нь тавихаас нааш юу ч шийдэж чадахгүй хэмээн шалтаг болгоод байгаа гол шалтгаан арилна. Гэтэл Нина ингэж бодож байжээ... Армийн командлагч нар үнэхээр бишрэмээр сүртэй догь харагддаг, гэхдээ тэд чинь улс төрийн бодлоготон, стратегичид, төрийн зүтгэлтнүүд, Максим бол улс төрийн бодлоготон, стратегичийн аль нь ч болохгүй, улаан цэрэгт жагсаалын сургууль л заана... Нэг хоёр!.. Нэг хоёр!.. За тэр, ханхар цээжтэй, улаа бутарсан хацартай, толийтол самнасан цайвар хүрэн үстэй эр өөрийг нь хүлээгээд зогсож байна. Савхин гутал нь гялалзана, товч нь гялалзана, шинэхэн суран бүс нь хяхарна, бүжиг хийхийн үес гутлынх нь төмөр тах зүймэл шалан дээр тожигноно. Сайхан хичээнгүй албан хаагч болно...

Харамсалтай хэрэг! Илүү юманд хүрч чадах л хүн. Дайн болбол бугдээрээ л дайтна, одоохондоо бол ажиллаж амьдрах хэрэгтэй байна. Нина энэ бүхнийг Максимыг цэргийн сургуульд орох гэж байхад түүнд хэлсэн билээ. Цаадах нь үгэнд нь ороогүй. Арга ч үгүй, Максим өөрийн бодолтой байх, өөрийнхөө дураар шийдэх эрхтэй. Гэтэл бүсгүй ч гэсэн хувь заяагаа өөрөө шийдэх эрхтэй шүү дээ. Тэгээд Нина Москвагаас явахгүй, Максимтай суухгүй гэж хатуу шийдсэн ажээ.

Вахтанговын театрт гол дүрд нь бүдүүн пагдгар Горюновыг тоглуулж “Гамлетийг” найруулан тавьжээ. Юра Шарок тэр театрынханд дуртай тул Вадим Марасевичид утасдаж жүжгийн билет олж өгөхийг гуйгаад тэднийд орой очно гэж хэлжээ.

Москвагийн нэрд гарсан дотрын эмч профессор Марасевич Гагарины гудамд байдаг Эрдэмтдийн ахуйг сайжруулах төв комиссын эмнэлэгт сард нэг удаа зөвлөлгөө өгдөг бөгөөд түүнд үзүүлэх гэж хагас жилийн өмнөөс захиалга бичүүлдэг ажээ. Пироговын гудамжны эмнэлгийг профессор Марасевичийн эмнэлэг, Анагаах ухааны дээд сургуулийн тэнхимийг профессор Марасевичийн тэнхим гэгцгээнэ. Тэрээр гагцхүү ойр дотнынхоо хүмүүсийг гэрээрээ үзнэ. Удам судар яривал украины аль нэгэн гетман элэнц хуланц нь байсан Марасевич мөн профессор эмч агсан эцэг шигээ Москвагийн сэхээтнүүдийн дотор эрт дээрээс уламжилсан тогтвортой хэлхээ холбоотой, Москвагийн унаган хөвгүүн билээ. Староконюшенный гудам дахь тэдний гэрт Игумнов, Станиславский, Прокофьев, Нежданова, Гельцер, Качалов, Сумбатов-Южин, Мейерхольд энэ тэр ирцгээнэ, бас Луначарский ч орж гардаг байжээ. Тоглолтоор яваа өрнөдийн аль ч нэрт жүжигчин, ид шохоорхол татаж байгаа аль ч дуучин чинээлэг боловч эмх замбараа муутай энэ айлаар орохгүй гарна гэж байхгүй. Зочдоо ганган охин нь угтана. Дарайтал цардсан бүтээлэг дэлгэж, дээд зэргийн болор эдлэл гаргана. Голдуу л тоглолтынхоо дараа ирдэг залуухан жүжигчид тугалын мах, хулд загасны ягаан мах энэ тэр лүү амтархан орж явчихна. Залуучууд бүгдийг бужигнуулж өгнө. Заримдаа хоолны ширээнээс босоогүй байж л шууд зохион бодож, товч үзэгдэл жүжиглэцгээнэ. Вадим тэр даруй цээжээр шүүмж хэлэхэд тэр нь профессор Марасевичид яггүй хурц ярьж байх шиг санагдана. Вадим их сургууль төгсөж, урлаг судлаачийн диплом авсан, лекц уншиж, заримдаа экскурс хөтөлдөг, харин одоо бол театрын шүүмжлэгч болох гэж оролдож байгаа аж.

Профессор Марасевич боржом рашаан балгаж суух завсар эв нь таарвал өөрийнхөө буюу эцгийнхээ эмчилгээний практикаас нэг хоёр хөгтэй явдлын тухай ярихаас буцахгүй, гэхдээ арван хоёроос хойш удаан суух дургүй, өөрийн нь мэргэжлийн хүмүүс дэглэм сахих ёстой хэмээгээд бүгдээрэнд нь тавтай нойрсохыг ерөөж өрөө рүүгээ явна.

Вика нь бас театр, кино хоёрт өөрийгөө сорьж үзсэн боловч нэртэй жүжигчид, найдлага төрүүлж байгаа найруулагчид, санасандаа хүрч байж салдаг сэтгүүлчид энэ тэртэй хайр сэтгэлийн явдал жаал тогтоосныг эс тооцвол одоогоор олигтой болсон юм үгүй байлаа. Тэдгээр хайр сэтгэлийн явдал нь цэцгийн баглаа, захидал бичиг, зоогийн газар, такси унаа гэхчлэн их л дээгүүр эхэлдэг бол хэрүүл маргаан хийж, харилцан муудалцаж, утсаар тайлбар тавиад дуусдаг билээ.

Тэр амрагийн ажил ганцхан Юра Шароктой л элдэв намжиргүй эхэлж, мөн тийнхүү ердийн байдлаар дуусжээ. Тэр хоёр Арбатад санаандгүй тааралдаж, хаврын наранд ээвэр талаар нь ханиндаа жаахан явсны эцэст Юра,

–Манайд орёе, миний яаж суудгийг хар л даа гэж хэлжээ.

Айлд орж хүн яаж суудгийг харна гэдэг нь юу гэсэн үг болохыг Вика сайн ойлгож байжээ.

Гэвч энэ маягаар урьсан нь түүнийг шууд уургалжээ. Түүнээс гадна Лена Будягинатай нууцаар өрсөлдөх сэтгэл нь бас түлхсэн хэрэг. Юра, Лена хоёр уулзахаа больсныг тэрээр мэдэхгүй байжээ.

Юра яаж аж төрж суудагтай танилцах “ажлыг” тэр хоёр олон жил явж байгаа юм шиг элдэв олон таван үггүй амжуулцгаав. Нөгөө их юм үзэж, одоо байгалиас заяасан зөнгөөсөө давахаа больж яваа бусад хонгоруудтайгаа жишихэд Юра зохих түвшинд байжээ. Гэтэл энэ өрөө, энэ хариугүй байр, эцгийнх нь хэн гэдгийг санагдуулж байгаа энэхүү индүүдсэн даавууны үнэр энэ тэр даанч...

Бүсгүй Юраг наалдаад салахгүй, хөөж зайлуулах хэрэг болох байх гэж боджээ. Тэрээр хүн хөөхийг ганц бие эр хүн рүү гудиггүй ордог шигээ юман чинээ бодохгүй. Гэтэл Шарок бузгай хүн юмсанж. Нөгөө оёдолчны хүү гэсэн чинь ийм эр байдаг байна!

Харин Юра хүүхний аяыг бушуухан дагасан нь учирсаад байх юмгүй байж. Хүйтэн биетэй, маанаг гэлтэй тэр хүүхэн түүний сэтгэлийг огт хөдөлгөсөнгүй. Мань хүн түүнийг бас Ленатай харьцуулж үзэж л дээ. Гэтэл дээрдэх юм байсангүй. Үгүй тэр, хүний ор луу хэнэггүй орж байгааг нь! Тэгж бодохоос завхай юм болгоныг авгайтайгаа зүйрлүүлж үздэг бэртэгчин хүний хор шар буцлаад ирэх нь тэр. Юра өнөөдөр бол Вадим дээр “Гамлетийн” билетийн талаар иржээ.

–Юмхан амсах уу гэж Вадим санал болгов.

Тэр хоёр Шарокийнхны бүх байрнаас илүү зайтай тэдний хоолны өрөө рүү орцгоолоо.

Паравгар уруултай, жижигхэн нүдтэй, шилүүснийх шиг сахлаг хөмсөгтэй Вадим тун хомхой идэж гарлаа. Гадаад төрх нь ийм байтал дуу хоолой нь гайхмаар, сэхээтэн хүний уяхан уянгатай эр хонгор дуу.

Вадим шөл идэж байгаа хэрнээ талханд цөцгийн тос зузаан гэгч нь турхэх зуур,

–Тэр нөхөр чинь шүүх эрхийг (юрисдикция) хууль цаазтай (юриспруденция), ховор нандин зүйлийг (раритет) тэнцвэртэй байдалтай (паритет), тохиолдсон явдлыг (прецедент) өрсөлдөгчтэй (претендент) хооронд нь хольж хутгана шүү дээ. Гэтэл тэр чинь шинэ хүн, түүнийг гавшгайч гэнэ үү, шинэ дайчин гэнэ үү, юу гэж нэрлэх нь хамаа байхгүй. Өөрийн гэсэн сэдэвтэй, зүгээр ч үгүй гол сэдэв шүү, өөрийнхөө баатартай гарч ирж байгаа юм, баатар нь ирээдүйн баатар шүү. Ингэхлээр бид манай ирээдүйг зуун грамм цөцгийн тосоор сольчихно гэж үү дээ! гээд тосныхоо савыг цааш нь түлхсэнээ,

–Гэтэл тэр гашуудагсад чинь чухамхүү энэ зуун граммаар гашуудаж байгаа шүү дээ гэв.

Ирээдүйн баатруудын тухай Вадимын яриа Юрагийн үл мэдэх тэр ертөнцийн тухай мэдлэгт эрхбиш юухан ч гэсэн нэмэрлэж байгаа тул тэрээр нэг их дургүй ч үгүй сонсов. Саяхан Вадим яг эсрэг юм ярьж, уран чадварыг дөвийлгөн магтаж, муу дурыг зүхэж байсан юм. Тэрээр сайн муу юмны ханшийг андана гэж байхгүй, хэзээнээсээ хүчтэнийг бараадах дуртай болохоор дунд сургуульд байхдаа Саша Панкратовоос, их сургуульд байхдаа бас нэг хүнээс

салдаггүй байсан бол одоо дүйнгэтүүлэх яруу найргийн тухай өгүүлэл бичдэг нэг нэрд гарсан шүүмжлэгчийн дэргэд байх болжээ. Гэхдээ Юра Вадимыг тууштай биш байхыг олж үзээгүй. Марасевичийн гэр, жүжигчид, бодох санаашрах юмгүй нэр цууд гарсан хөгжилтэй олон хүн энэ тэр Юрад сайхан санагдана. Тэрээр алдар гавьяандаа эрхэлсэн энэ улсын ярианд шижээргүй хөнгөмсөг янз байгааг олж мэдрэх агаад тэгснээсээ болж тэдний алдар гавьяа овжин аргаар санаандгүй олдсон ойр зуурын хөнгөн шингэн юм шиг санагддаг болой. Тэд нар хээ шаагүй юм шиг хэрнээ хэн ч халдашгүй дархан амьтад шиг байцгаадаг билээ.

Толиотой сайхан царайтай, эрүүндээ дэгжин сахалтай, зөөлхөн булбарай гартай, язгууртан шинжтэй, мөн л халдашгүй дүр төрхтэй профессор Марасевич Юрад бас л сайхан санагдана. Юра, Вадим хоёр одоо бараг өдөр болгон тааралддаг болжээ. Вадим түүнийг театрт оруулж өгнө. Юра Вадимгүй ганцаараа ч театр явна. Түүнээр юм уу түүний гэрт танилцсан хэн нэгнээр утасдуулж байгаад л явчихна.

Ёстой сайхан цаг! Гучин дөрвөн оны хавар Юра Шарокийн сэтгэлд удтал хоногшин үлджээ. Прокурорын газар түүний нэрийг одоохондоо батлаагүй байгаа. Гэхдээ Малькова тун удахгүй бүх юм шийдэгдэнэ гэж амласан. Юра санаа зовох юмгүй, эрх чөлөөтэй явах сүүлчийн хэдэн сараа дуусгаж байгаа тул аль болохоор сонирхолтой өнгөрөөхийг хичээнэ. Гагцхүү Ленагийн тухай дурсан бодохуйд сэтгэлийн тав алдарна. Тэрээр театр ороод бүсгүйг олж харахаасаа айвч бас мөн олж харахсан хэмээн горьдож үзэгчдийн танхимаар хараа бэлчээнэ.

Лена өвдсөнөөсөө хойш театрт нэг ч удаа юм үзээгүй байжээ. Тэрээр гэрээсээ бараг гараагүй, хэнд ч утасдаагүйн гадна Сашагийн талаар захиа бичицгээх гэж байсан тэр өдрөөс хойш нөгөөдүүлтэйгээ ч тааралдаагүй ажээ.

Өнөөдөр Гера Третьяк түүн дээр санаандгүй хүрээд ирэв. Тэрээр мөн элчин сайдын охин бөгөөд тэр хоёр бага байхдаа үерхэж, заримдаа Лондон, Парис, Берлин энэ тэрд цуг явж таарч байсан, харин Москвад ирсээр бараг сураг тасарсан юмсанж.

Гера ухаан сэргэлэн, хэл ам хурц, бараан үстэй аятайхан бүсгүй. Тэрээр шал дэмий аар саархан юмыг хүртэл тун донжтой ярьж чаддаг тул Лена түүнийг сонсон инээмсэглэн суув. Нэг удаа өмнөд Уэльс руу цуг явж Кардиффт хямдхан буудалд бууснаа дурсацгаав. Тэр буудалд бас Шотландын хөл бөмбөгчид буудалласан байж таараад тэдний хоёр нь эмэгтэйчүүдийг арван дөрвөн наснаас нь хүнтэй суухыг зөвшөөрдөг нэг орон руу оргож явцгаахыг тэр хоёрт санал болгосон билээ. Лена, Гера хоёр тэгэхэд дөнгөж арван тав хүрээд байсан. Фонтенбло ордныг явж үзэхэд тайлбарлагч хүүхэн Наполеоны орыг үзүүлээд түүний чацыг метр тавин хоёр сантиметр байсан гэж хэлж байсныг санацгаав. Гера гайхахдаа метр жаран хоёр байлгүй гэсэн. Гэтэл нөгөө авгай дорхноо гомдож, нөхрийнх нь чац метр тавин хоёр сантиметр, түүнийг Наполеонтой адилхан чацтайг нийтээрээ мэднэ гэж билээ.

Тэр нь яагаад ч юм бэ, одоо жигтэйхэн инээдэмтэй санагдаж мань хоёр баахан хөхрөв. Гера ирж нэг оройг өнгөрүүлсэнд Лена баярлаж суулаа. Явахад нь түүнийг тэврэн үнсээд гунигтай гэгч нь “Чи намайг битгий мартаж бай л даа” гэж өгүүлэв.

Варя, Нина, Макс гурав Улаан Армийн ордонд бүжиглэж, Юра Вадим Марасевичийнд оройн зоог барьж, Лена Будягина дээр Гера Третьяк зочилж ирсэн тэр нэгэн орой найман цагийн орчим Софья Александровнад нэг хүн утасдаж, маргааш өглөө арван цагт Бутырын шоронгийн захиргаан дээр ирж Александр Павлович Панкратов хэмээх хүүтэйгээ уулзах хэрэгтэй гэж хэлжээ. Дулаан хувцас, мөнгө, хүнсний зүйл авч очих ёстой гэнэ. Ярьсан хүн нь өдрөөс өдөрт товч тодорхой хэдхэн зүйл хэлж дадсан төлөв тайван дуутай хүн ажээ. Тэгээд хэлэх юмаа гүйцэнгүүт юм асууж барихыг хүлээлгүй харилцуураа тавьчихав.

Тэр хүн ямар нэгэн чухал тоймтой юм хэлэхээ мартаж дутуу ярьчих шиг Софья Александровнад санагдан үүнээс болж бүх юмыг нь ёсчлон бэлтгэж чадахгүй болох нь гэж айж орхилоо. Юм мартчих вий, будлиулчих вий гэж айхдаа саяын хүний хэлсэн бүх юмыг тогтоож авах гэж бачимдан мунгинав. “Маргааш, арван цагт, Бутыркад, уулзалт, дулаан хувцас, хүнс, өөр юу билээ... Ээ халаг, мартчихлаа, өөр юу билээ... өө тийм, мөнгө, замд хэрэглэх мөнгө...” Тэгээд Софья Александровна юм мартахгүйн тулд нэгд нэгэнгүй цаасан дээр тэмдэглэн авав. Мөнгө, хүнсний зүйл гэдэг нь цөллөг гэсэн үг. Дулаан хувцас гэдэг нь Умард нутаг буюу Сибирь гэсэн үг.

Бүх зүйлийг шөнөдөө багтааж эмхэлж бэлтгэх хэрэгтэй болсон тул Софья Александровнад цөхөрч суух цаг байсангүй. Гагцхүү хүүгээ ингэж магадгүй гэж урьдаас юм бэлтгэх нь муу ёр гэж санаад юу ч бэлтгээгүй байсандаа өөрийгөө түмэнтээ буруутган гэмшив. Саша өвлийн пальто, үстэй малгай, ноосон цамц, зузаан ороолттой явсан, харин эсгий гутал байхгүй, гэхдээ түүнийг хааш нь ч цөлсөн бай одоо дөрөвдүгээр сар юм чинь энэ удаа эсгий гутлын хэрэггүй. Өвөл л хэрэг болно, тэр болтол эсгий гутал явуулчихна. Одоо бол түүнд савхин гутал л хэрэгтэй. Тэнд шавар шавхайтай учраас муу шаахайтайгаа явбал бүр баларна, ганц хэрэг болж аминд орох юм чинь савхин гутал. Гэтэл Сашад савхин гутал байхгүй. Нэмэрт нь дэлгүүр аль хэдийн хаачихсан, онгорхой ч байсан савхин гутлыг бичгээр өгдөг юм чинь өөрт нь бичиг байхгүй юм чинь. Барааны зах дээрээс тэнгэрт хадсан үнээр авч болно, гэхдээ савхины оронд картонон гутал атгуулчихсан байхаас буцахгүй газар. Гэвч зах бас аль хэдийн хаачихсан. Тэгтэл Вера эгчид нь яг Сашад таарах дөчин размерийн хээгүй бөх савхин гутал зуслангийнх нь байранд байсан нь санаанд оров. Дараа нь ямар ч үнээр хамаагүй тэд нарт савхин гутал олоод өгнө, одоо тэр байгааг нь Сашад өгөх хэрэгтэй.

Тэгээд Вера руу утасдлаа. Вера нөхөртэйгөө зуслан руугаа яваад өгсөн, нөгөөдрөөс нааш ирэхгүй гэнэ. Ийм азгүй юм байх гэж!

Дүү Полина нь гэртээ утас байхгүй. Уул нь хажуугийнх нь айл утастай. Полина тэр айлынхантай найзалдаг байх үеэс Софья Александровна тэр утасны дугаарыг мэддэг боловч түүнийг дуудаж өгөхөө больсоор хэдэн жил болж байгаа, бас Полина ч өөрөө битгий утасдаж байгаарай гэж захисан билээ. Софья Александровна тэр айл Полинаг дуудаж өгөхгүй, тэр ч байтугай загнах байх гэж санаа зовж байсан боловч арга буюу утасдлаа.

Харилцуураас эрэгтэй хүний сэргэлэн дуу сонсдов.

–Өршөөгөөрэй, танд төвөг удаж тусгүй юм болж байна, даанч яаралтай хэрэг гараад... Та Полина Александровнаг дуудаж яриулж өгөхгүйсэн болов уу? гэж Софья Александровна гуйв.

–Ямар Полина Александровна вэ?

–Танай айлын хүүхэн, хорин зургадугаар байрных, та намайг өршөөж үзээрэй, би эгч нь юм.

–Юу гэнэ вэ, та чинь...

Гэвч тэр хүн утсаа тавьсангүй, харилцуурыг эмэгтэй хүн авлаа.

–Танд хэн хэрэгтэй юм бэ?

–Та намайг өршөөж үзээрэй хэмээн Софья Александровна царайчлан өгүүлж –Танай айлын Полина Александровнагийн эгч ярьж байна аа. Энд нэг тоогүй юм болж, тун яаралтай хэрэг гараад, юу яагаад... Та надад миний дүүг дуудаж, хичээж тус болж өгөхгүйсэн болов уу гэв.

–За хэмээн хүүхэн дурамжхан дуугарав.

Софья Александровна зөндөө хүлээсний эцэст Полина утсан дээр ирэв. Тэрээр Сашад муу юм болж гэдгийг гадарлаад сандарчихсан бололтой байв.

–Сашаг маргааш цөллөгт явуулах гэж байна. Верагийн зуслан руу явж савхин гутал авчрах хэрэгтэй байна гэж Софья Александровна хэлэв.

–Ээ гай, ээ гай хэмээн Полина уулгалан дуу алдаж, –Игорь маань халуунтай байгаа, гэтэл Коля арван нэгээс хойш ирнэ. Яадаг юм билээ? Коляг эргэж ирэнгүүт би танай руу очъё, харин зуслан явж амжихгүй болчихно шүү дээ гэв.

–За яахав, хүрээд ир, юм бэлтгэхэд тус болно биз. Савхин гутлын тухайд би л нэг арга бодохоос биш гэж Софья Александровна хэлэв.

–Юу авч очих вэ?

–Юу ч хэрэггүй, бүх юм байна.

Гудамж гэх юм байхгүй зөвхөн зөрөг замтай зуслангийн шинэхэн тосгон дундуур хаагуур явахаа харанхуй шөнөөр олох эсэхээ мэдэхгүй ч гэсэн тийшээ өөрөө л явах хэрэг болж дээ. Гудам зөргийнх нь нэрийг хэн ч мэдэхгүй, байшингуудынх нь дугаар холилдчихсоныг хэлэх үү, бас тэгээд айлууд зусландаа гараагүй болохоор асууж сураглах ч хүн олдохгүй дэг ээ. Гэвч явахаас өөр арга байхгүй. Гэтэл өөрөө зуслан руу яваад өгвөл дэлгүүрт хэн явах билээ? Тэрээр Варя руу утасдлаа. Варя эзгүй байлаа, Нина ч бас байсангүй. Милица Петровнаг гуйх уу? Зүрхээ хайрлаад явахгүй л дээ, жаахан сүүтэй бидон ч барьдаггүй юм чинь, хүнсний юм зөндөө авах хэрэгтэй байхад тэр нэмэргүй. Талх, хатаасан талх, саахар, лаазалсан өтгөн сүү, витаминь дутагдалд орчихсон учраас нимбэг, бас утсан хиам, бяслаг, гахайн утмал мах авах хэрэгтэй... Энэ бүхнээ цаасан дээр жагсааж бичээд Михаил Юрьевичийн хаалгыг тогшив. Цаадах нь халаадтай, ширээн дээрээ тонгойчихсон нэг юм нааж байв.

–Тун эвгүй л байна, даанч өөр арга алга. Энэ нэрс нь байна, мөнгө энэ, сайн утсан хиам байхгүй бол дутуу утсаныг авч болно, цаг агаар ийм байхад муудахгүй, бас загасны төрлийн юм олбол зүгээрсэн, гэхдээ дэндүү шорвог юм бол хэрэггүй.

Михаил Юрьевич хавчмал шилнийхээ дээгүүр түүн рүү ширүүн харлаа.

–Та чинь харанхуй шөнө хотоос гадагш яаж явах хүн бэ? Тэгээд хэзээ эргэж ирэх болж байна?

-- Би шөнийн суудлаар эргээд ирнэ, нэг цаг өнгөрөсхийгээд явдаг юм.

-- Трамвай зогсчихсон шүү дээ. Аргалаад яваад ирнэ ээ.

-- Та дэлгүүртээ яв, би эгч рүү чинь оччихоод ирье гэж Михаил Юрьевич хэлэв.

-- Юу гэсэн үг вэ? Михаил Юрьевич минь, зөндөө хол шүү дээ, дөчин наймдугаар километр. Буудлаас минут явган явна, тосгонд гэрэл гэгээ ч байхгүй, зам харгуй ч бэрх, шавар шавхай ч их, та юу хэлж байна, тэгж болохгүй, таныг алчих ч юм билүү.

–Хаягаа хэлчих, чадвал замыг нь зурчих, би хувцсаа өмсөөд орхиё гэж Михаил Юрьевич хэлэв.

Софья Александровна чадах чинээгээрээ зурж байдаг хэрээрээ тайлбарлав. Галт тэрэгний зогсоолын дэргэд мухлаг бий, өвөл мод бариад хадчихдаг юм, тэр мухлагны баруунтайхнуур зүглэнэ шүү, тэгвэл яг нөгөө хэрэгтэй зөрөг рүүгээ орчихно. Зөргийг л олох хэрэгтэй, гол нь тэр. Түүнийгээ олчихсон хойно бол зүүн гар талаасаа гурав дахь гудамж, ер нь ч Гуравдугаар ногоон гэдэг нэртэй юм, даанч хаяг байхгүй л дээ, хүүхдүүд зун ховх татаад үгүй хийчихсэн байна билээ. Зуслангийн байрны дугаар нь хорин зургаа, хаалган дээрээ бичээстэй байгаа. Хашааг нь танихад амархан. Наад цаад хоёр талд нь битүү хашаа, дунд нь хайсан хашаа байгаа, тэр нь яг Верагийн зуслан. Харин хамгийн гол юм мухлагнаас л шууд баруун тийшээ зүглэх хэрэгтэй.

Михаил Юрьевич давхац гуталтай, донхор үстэй малгайтай, хуучин янзын хавчмал шилтэй, хөмсөг зангидан додигор зогсож харагдавч эль хуль шавар шалбаагтай гацаагаар бэдэрч явна гэж санавал арчаагүй байхаар санагдана. Шөнөжингөө эрж хайж ч магадгүй, гэтэл өглөө ажилдаа явах ёстой хүн. Софья Александровна цагаа хартал яг ес арван тав болж байсан тул дуу алдав. Жижүүрийн дэлгүүр аравт хаана.

Трамвай дүүрэн хүнтэй байсан тул Софья Александровна торговол торгог, хөөж гаргахгүй нь лав гэж бодоод хоёрдугаар вагоны урд үүдээр ороход хэн ч түүнийг торгосонгүйд тэндээ зогсоод билетийнхээ мөнгийг дамжуулав. Дэлгүүрийн дараа зөндөө ажил байгааг бодов. Чемоданаа ойр найр хэрэглээгүй болохоор цоож нь бүтэн эсэх, түлхүүр нь хаа байгаа энэ тэрийг ч мэдэхгүй ажээ. Цоожгүй бол болохгүй. Саша эрүүгийн ялтнуудтай нэг хэсэгт таарчихаж магадгүй, тэгвэл цаадуул нь хамаг юмыг нь хуурайлчихна.

Саша нь эрүүгийн ялтнуудтай цуг таарч хамаг юмаа алдаж доромжлуулж, зодуулж магадгүй гэж бодохоос хүү нь ингэж тамлуулж, хөөгдөх туугдахдаа хүрч, ад үзэгдэн, эрх мэдэлгүй

болтлоо их зовлонд нэрвэгдсэнийг Софья Александровна дахин мэдрэв.

Одоо түүний явж байгаа энэ Москва хот, энэ их бөөн гудамж талбай, гэрэл гэгээ, машин трамвай, дэлгүүрийн үзэсгэлэн энэ тэр шал хуурамч мэт санагдана. Лаваар хийсэн хувцас өмсгөдөг хиймэл хүнээс авахуулаад бүх юм хар дарсан зүүдэнд байгаа юм шиг агаад трамвайны цагаан гэрэлд сүүтэгнэн хөдөлж, нэгэн зүгт жирэлзэн довтолгох ажээ.

Тэрээр Охотный ряд гудамжны тэнд трамвайнаас буулаа. Аравт арван тав дугуу байна. Дэлгүүрийн үүдээр хүн явж байхыг зогсоолын тэндээс үзэв. Онгорхой байна! Яарсандаа түргэн түргэн алхаж амьсгаадан явав. Тэгээд дэлгүүрийн үүдэнд ирмэгц хүн оруулахгүй хэдийн хаалгаа барьчихсан, баахан улс бөөгнөрөн, минут хүрэхгүй хоцорсондоо хорсож хараал зүхэл тавьцгааж байхыг үзэв. Зарим нэг нь чихэлдээд орчихыг оролдовч чадахгүй байна. Бүдүүн худалдагч авгай хаалгаа барьжээ.

Софья Александровна бас чихээд орчих гэж үзсэн боловч даанч чадсангүй. Цөөвтөр ч гэсэн хэрхэндээ оволзож байгаа тэр хүмүүс түүнийг дор нь шахаад гаргачихжээ. Дараа нь хүмүүс цөөрч дэлгүүрээс тарах хүний хөл сийрсээр доторх гэрэл бүдгэрээд явчихлаа. Тэг тэгсээр цөм тарж одов. Ганцхан Софья Александровна л зогссоор байна. Тэрээр хаалга онгойх тоолонд худалдагчаас оруулахыг гуйна.

Осгоруутсан минчгэр улаан царайтай худалдагч авгай паргиа дуугаар,

–Ээж гуай, та зай болоорой, битгий саад хийгээрэй! гэхээс өөр юм эс хэлнэ.

–Гайгүй шүү дээ, би танаас гуйж байна. Дэлгүүрээс хэсэг хөгжилтэй залуус шавааралдан гарч ирж, нэг нь сэргэлэн гэгч нь,

–Ганц шил юм авах гэсэн авгайг оруулаач! гэж хашгирав.

Тэгээд хөгжилтэй залуус Охотный ряд гудамж руу гүйлдэцгээв.

–Би танаас гуйж байна шүү дээ, одоохондоо орж болохоор л байна хэмээн хаалга онгойх бүрд Софья Александровна царайчлан гуйсаар байв.

Хаалга цоожилтол ингэж шалаад салдаггүй зөрүүд амьтад орой болгон таардаг юм чинь худалдагч авгай дасчихсан болохоор түүнийг огтхон ч тоосонгүй.

–Битгий дайраад бай! Хаалганаас холд! Цэвэрлэгч авгай нар шар үртэс асган шалаа шүүрдэж худалдагч нар лангуун дээрээс бараагаа хурааж яарцгааж харагдана. Софья Александровна зогссоор л байв. Хаалга барьж байсан авгай хамгийн сүүлчийн хүнийг гаргаад цаашаа явав. Софья Александровна хаалгыг түлхээд дотогшоо орж явчихлаа.

–Хаачих нь вэ?! гээд нөгөө бүдүүн авгай гүйж ирэв.

–Би гарахгүй ээ гэж Софья Александровна аяархан өгүүлэв.

–Одоохон хэсгийн цагдаад тушаачихна аа! гэж бүдүүн авгай сүрдүүлэв.

–Хүүдээ, шорон руу юм аваачиж өгөх гэсэн юм хэмээн Софья Александровна гудамжны жаварт мөхөөлдөс, хуушуур зардаг энэ худалдагч авгайн осгоруутсан муухай царай руу харж, –Маргааш хол явуулна, замын хүнс бэлтгэх хэрэгтэй байна гэв.

Худалдагч авгай санаа алдав.

–Цөмөөрөө худлаа ярина, цөмөөрөө л ямар нэг юм хэлнэ. Бидэнд чинь бас амралт байх ёстой шүү дээ.

Софья Александровна дуугарсангүй.

Хүүхнүүд пальтогоо өмсөн цүнх, тороо эмхэлнэ.

–Михеева, мөнгий нь аваад орхи! гэж худалдагч авгай тэртээ булан руу хашгирав.

Полина ирэв. Бүр шөнө орой болсон хойно Михаил Юрьевич, Вера хоёр гутал авчирлаа. Тэгсэн чинь дөч биш дөчин нэгэн размер юмсанж, гэхдээ л хэрэг болно.

–Гоёлын хром биш ажил аяны хар гутал. Ноосон оймстой дулаахан ч, эвтэйхэн ч, тэгээд сайхан таарна гэж Вера ярилаа.

Вера гутлаас гадна өргөн оосрыг нь сааж сунгаж болдог үүргэвч авчирчээ.

–Идэх юмаа үүргэвчинд, хувцас хунараа чемоданд хийчих.

Эгч дүү гурвын дотор хамгийн шаламгай, юманд эв дүйтэй нь Вера бөгөөд их хотын хаяанд байдаг улс шиг ажилсаг гавшгай билээ. Хар хүн нь анчин, загасчин, хүүхдүүд нь цаначид, тойрон аялагчид, зусландаа аж төрж цэцэрлэг, ногооны ажлаа янзална. Тухайн үедээ Софьяг нөхрөөс нь салгах гэж зүтгэн “Чи дэндүү номхон амьтан юм” гэж үглэдэг байжээ. Тэгээд дүүгээ өмөөрөн Павел Николаевичтэй муудалцдаг байсан мөртлөө түүний үгийг даадаггүй, эцсийн бүлэгт Панкратовынхоор орохоо больсон юм.

Вера өөрөө бүх юмыг сайхан чадмаг сурамгай эмхлэн янзалж, халбага, сэрээ, хутга, сэнжтэй аяга өгөх хэрэгтэй гэв. Софья Александровна ийм юмнуудыг таг мартчихаж. Бас сахлын хутгыг нь мартчихаж. Эргэлтээр оруулдаг юмаа л бэлтгэж байгаа царай нь тэр, одоо чинь замд хэрэглэх юм эмхэлж байгаа учраас юу ч өгч болно, зөвшөөрнө шүү дээ.

–Өөрт нь их мөнгө өгөхийн хэрэггүй хэмээн Вера сургамжилж, –Замдаа хулгайд алдчихаж мэднэ, дараа нь тэр газар луу нь гуйвуулсан нь дээр. Маргааш уулзахлаараа очингуутаа цахилгаан өгөөрэй гэж хэл, чи тэгээд өөрөө хүлээн авах гэсэн хаягаар гуйвуулчихна биз. Дажгүй ээ, залуу хүн тэснэ! гэв.

Гэхдээ Верагийн энэ үг биш, харин юмыг жин тан янзалж ажил хэрэгч эрч хүч ундарч байгаа нь сэтгэл тайвшруулна. Чухамхүү амьдрал энэ бөгөөд энэ нь ч Сашаг мөн амьдралд бэлтгэж байгаа болой.

Софья Александровнагийн гэрэл асаатай байсныг Нина анзаарсангүй, харин Варя үзэж анзаарсан ажээ. Гэвч Софья Александровна заримдаа шөнөжин гэрэлтэй хонодог, энэ тухай өөрт нь ярьж байсан болохоор тэрээр төдийлөн нэг их тоосонгүй. Нэмэрт нь түүний толгойд маргааш орой Макс, Серафим хоёрыг үдэж мордуулахаар төмөр замын буудал руу явна гэдэг ганц бодол эргэлдэж байлаа.

Улаан Армийн ордны бүжиг шөнийн хоёр цаг хүртэл үргэлжилжээ. Трамвайнд амжиж суухын тулд олон хүн эрт явахад Нина бас явъя гэж санасан боловч Варя, Серафим хоёр түүнийг үлдээх гэж ятгажээ. Макс үнэн цагаан сэтгэлээсээ инээгээд юм дуугарсангүй. Нина ганцаардаж тэр хоёрын үгэнд орсон юм байж.

Тэд нар шөнийн хүйтэн Москвагаар явган явцгаав. Варя галошгүй бас нимгэн алчууртай. Серафим түүнд цуваа нөмөргөж цэрэг малгайгаа өмсгөсөнд цаадах нь гудамжны гэрлийн дэргэд бяцхан толиндоо тольдож харлаа. Малгай нь томдоод дух руу нь бүрхэж орж ирчихээд байвч зохиж байгаа гэдэг нь тун догь, харахад хөөрхөн залуу цэрэг болжээ. Серафим Варягийн мөрөн дээгүүр өрөөсөн гараараа тэврээд Макс, Нина хоёрын ард нь яваа бөгөөд урьд хоёрыгоо булан тойрох үед үнсэлдэнэ. Серафим уруулыг нь өвдтөл озох ажээ. Варя хэзээ ч жинхэнэ ёсоор үнсэлдэж яваагүй тэгээд чиг одоо үнсэлдлээ гээд сайхан оргих юм ерөөсөө байхгүй, гагцхүү өвдөхийг л мэдэрнэ. Гэхдээ энэ юу гэсэн үг вэ гэдгийг ойлгож байв. Энэ бол Серафим тачаалтай гэсэн үг. Серафим, Варя хоёр яагаад хоцроод байгааг Нина гадарлаж байсан байх, гэхдээ юу ч анзаараагүй царайлна. Гэртээ ирсэн хойноо ч элдвээр үглэж аашилсангүй, гагцхүү маргааш ажилтай учраас бушуухан гэрлээ унтраагаад хэвт гэжээ.

Нина өглөө нь Варягийн ангийн багшид “Варя Ивановад ар гэрийн шалтгаанаар гуравдугаар хичээлийн дараа чөлөө олгохыг хүсье” гэж зурвас бичээд ширээн дээр үлдээв. Ар гэрийн шалтгаан гэдэг нь Макс, Серафим хоёрыг үдэх ажил юм. Гэвч Варя сургуульдаа явах тухай бодохыг ч хүссэнгүй. Тэрээр буудал дээр аятайхан хувцастай очмоор санагджээ. Төгсөгчид явцгааж байгаа болохоор үдэх улс олон байх болно, өчигдрийн Улаан Армийн төв ордонд үзсэн сайхан хувцастай гоё охидууд ч очно, тэгэхлээр Варя ирээдүйнхээ нөхрийг үдэж мордуулах гэж байгаа юм чинь тэднээс дутуугүй хувцаслаж, нас бие гүйцсэн түвшин хүн харагдах ёстой. Хар юм өмсөхгүй, чухамхүү түвшин, гэхдээ хүн анзаарахаар хувцаслана. Үсээ янзлуулж оо энгэсэг тавих хэрэгтэй, тэгэхлээр хоёрдугаар ээлжинд хичээллэдэг юм чинь гуравдугаар цагаас хойш гарна гэвэл юу ч амжихгүй гэсэн үг.

Тэрээр Нинад үдийн хоол бушуухан бэлтгэчихээд сурах бичгээ аваад Зоягийнх руу явжээ. Зоя бас хичээлдээ явалгүй, түүний үсээ янзлах, сормуусаа эрвийлгэх энэ тэрд туслалцав. Тэрээр ган аралтай өндөр өсгийтэй ганган шаахай, хамгийн гол нь өөрт нь хааяа өмсүүлж гадуур явуулдаг байсан ээжийнхээ далайн мигуйн арьсан дээлийг өмсүүлэхээр өгөв. Варя одоо түүнийг өмсвөөс Зоягийн хэлсэнчлэн далайн мигуйн арьсан хэвнэгтэй, ганган шаахайтай, мөн Зоягийн ээжийн цагаан алчуурыг зангидсан үнэхээр дуу алдам сайхан, насанд хүрсэн дориухан хүүхэн болжээ.

Варя тэгж тэгж дөнгөж таван цаг гэхэд бэлэн болоод Нина руу утасдав.

–Би шууд трамвайны буудал руу очъё.

–Чи хаанаас ярьж байна вэ?

–Сургуулиасаа.

Тэр хоёр трамвайны буудал руу зэрэг ирцгээв.

Нина түүнийг таньсангүй...

–Юун багт наадам бэ?

–Хувцасны өлгүүр хаалттай болчихоод Зоягийн пальто, алчуурыг авсан юм.

–Зоя яах билээ?

–Минийхийг өмсчихнө.

–Ном чинь хаа байна?

–Ширээндээ орхичихсон, буудал руу чирч явалтай биш дээ?!

Хувцасны өлгүүр хичээлийн үеэр түгжээтэй байж болох ч гэсэн Варя худлаа хэлж байгаа нь андашгүй байв. Үнэхээр Зоягийн пальтог өмссөн юм гэж санахад түүнийх ч гэсэн адилхан түгжээтэй байх ёстой шүү дээ. Гэвч Нина түүнийг хоргоож улайлгаж гэсэнгүй. Ямар жаахан хүүхэд биш удахгүй хүнтэй суучихна, Серафимтай суух гэж байгаа нь л яамай, зөв залуу шүү, тэгэхээр амьдралаа өөрийнхөө санаснаар зохионо биз, бас Серафимаа өөрийнхөө хүссэнээр л үдэж өгөг дээ.

Галт тэрэгний буудлын тавцан хүнээр пиг дүүрэн битүү байв. Нина, Варя хоёр яах учраа олохгүй тавцан руу гарах зам дээр хүрч зогсов. Тэгтэл Макс, Серафим хоёр тэдэн рүү хэдийн даллан тосон гүйж яваа харагдав. Тэгээд хэдүүлээ нийлээд суудлын галт тэрэгний хажуугаар битүү улсын хоорондуур чихэн замд хэрэглэх хүнс, ойр зуурын боодолтой юм барьсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаас шинель, малгайгаа вагондоо орхичихоод суран бүстэй цэрэг цамцтай толгой нүцгэн байгаа Улаан Армийн энэ цоо шинэхэн дарга нар, шагшим сайхан залуусыг цэцэг навчтай ирж, тэврэн үнсэж байгаа бүсгүйчүүдийн дундаас өөрснийхнийгөө хайгуулдан мөн л яарч бачимдаж яваа хүмүүсийн дотор бие биеэсээ төөрчих вий хэмээн болгоомжилсоор нөгөө хоёрынхоо вагон руу зүтгэцгээлээ... Идэр залуугийн ид хаваар баяр хөөр болж, шуугиж шаагисан хэрнээ тохьтой томоотой энэ залуус бол зөвлөлт улсын цэргийн догшин сүрт хүч юм. Нина тэднийг хараад чухамхүү энэ улаан хацартай сэргэлэн хөвгүүд тулалдаанд хошуучлан орж, хамгийн түрүүнд бүх юмыг биеэрээ амсах юм байна гэж бодов. Өөрөө ч гэсэн ийм амгалан, ийм тэнхээтэй Максимын дэргэд л байж байх ёстой болов уу гэж бас боджээ. Энэ маань ингээд явчихлаар түүний амгалан зан, цайлган сэтгэл үгүйлэгдэнэ дээ.

Серафим өөрийг нь хайрын харцаар ширтэж, бусад дарга нар мөн хараа гүйлгэж байгаад Варя сэтгэл хөөрөн бахдаж зогсов. Тэрээр санамсаргүй бараг Нина шиг өндөр болчихоод, энэ

хавьдаа хамгийн ганган бүсгүй нь байлаа. Түүн шиг дэгжин далайн мигуйн арьсан дээлтэй, гоё алчууртай хүн алга. Төмөр замын буудлын хөл үймээн, уурын тэрэгний сэтгэл татам нууц далдын алсын замд дуудсан дохио чимээнд Варягийн сэтгэл догдлон хамаг царай нь улаа бутарна. Макс түүнийг кино жүжигчинтэй адилхан байна хэмээж Серафим амь наснаасаа илүү хайртай гэж шивнэн, Нина хүртэл ийм дүүтэйдээ сэтгэл хангалуун инээмсэглэнэ.

Варя нас бие гүйцсэн сүйт бүсгүйн ёсоор Нина, Макс, Серафим гурвыгаа харахаас биш, ийш тийшээ сэлбэлзээд байна гэж хүн бодох вий хэмээн өөр хэн рүү ч эс харна. Эргэн тойрныг харж гэмээ нь тодорхой тэр гэсэн юмгүй, галт тэрэг болон галт тэрэг рүүгээ яарч яваа хүмүүсийг л бүхэлд нь зүгээр харж байв.

Тийнхүү зүгээр л зэргэлдээх тавцан руу хартал Сашаг үзэв.

Тэрээр хоёр цэргийн хооронд явж байв. Өмнө нь урт шинельтэй нэг жижигхэн дарга яаран бөөн улсыг ярж, ард нь мань хүн хоёр цэргийн хооронд үүргэвч үүрчихсэн, гартаа чемодантай явж байх ажээ.

Саша өөр дээр нь хүний хараа туссаныг мэдсэн юм шиг эргэж харахуйд түүний цаас шиг цагаан царай, цыганых шиг ногтон хар сахлыг Варя тодхон үзлээ. Цаадах нь явж байгаа цэргийн сонсогчид, Макс, Нина, Варя энэ тэрийг гүйлгэн харсан боловч хэнийг ч танихгүй цаашаа эргээд, тээр тэнд нэг тавцан дээр зогсож байгаа галт тэрэг рүү явлаа. Тэдний өмнө хойно шуудай, чемодан, хайрцаг барьсан хүмүүс яаран алхацгааж, зарим нь гүйцэж түрүүлэн тэг тэгсээр нөгөө хэд чинь олны дунд уусан алга болов.

Варя Сашагийн далд орсон зүг рүү харсаар л байв. Тэрээр дохионы хонх дуугарсныг ч сонссонгүй, хүмүүс салах ёс хийлцэж, Нина Максын духан дээр үнсэж, Серафим өөр лүү нь зүтгэн нүд рүү нь ширтэж байгаа энэ тэрийг ч анзаарсангүй.

–Варя, сэрээч! гэж Нина хэлэв.

–Би сая Сашаг харлаа.

–Юу гээд дэмий яриад байгаа юм бэ?! гэж Нина хашгирах шахам өгүүлснээ Варя үнэн юм хэлж байгааг гэнэтхэн ойлгов.

–Түүнийг харгалзагч нар авч явна, сахалтай болчихсон байна хэмээгээд Варя чемодан савтай гүйлдэж яваа олон хүний дотор Саша явсаар байгаа, тэгээд өөрөө түүнийг дахиад олж харж чадах юм шиг зэргэлдээх тавцан руу ширтсэн чигээрээ...- Сахалтай болчихсон байна, яг өвгөн хүн шиг гэж гүвтнэв.

Тэрээр нулимс асгаруулан мэгшив.

–Бүр хөгшин өвгөн...

–Болиоч, чи буруу таньсан хэрэг гэж Нина хоолой нь чичрэн өгүүлэв.

–Варя, чи эндүүрч байна, түүнийг ингэж явуулах учиргүй гэж Максим хэлэв.

–Хаанаас даа! Яг мөн байсан... Би таньсан... Тэр эргэж харсан, царай нь цав цагаан, бүр өвгөн хүн шиг байсан гэж Варя тасалдуулан өгүүлэв.

Балмагдаж гүйцсэн Серафим Варяд гараа өглөө.

–Варя, баяртай.

–Хувхай цагаан, яг үхсэн юм шиг цагаан! Тэгээд чемодан чирч явсан, цаадуул нь зүгээр явж байхад мань хүн чирч явсан... хэмээн Варя мэгшин уйлав.

Ичиж улайсан Серафим Варягийн сормуусны хар будаг зурваслан гоожиж, нулимсандаа норсон хацар дээр нэгэнтээ үнсэв.

Галт тэрэг зугуухан хөдөлж, сонсогчид зарим нь гишгүүр дээр, зарим нь үүдний тавцан дээр зогсоод гар даллацгаахад үдэж байгаа хүмүүс мөн гар даллан, элдэв ерөөл тавин хашгиралдаж, галт тэрэгтэй зэрэгцэн хошуурцгаав. Макс мөн гар даллаж байна. Серафим ч бас даллах ажээ.

Харин Варя буудлын тавцангийн голд уйлсан хэвээрээ алчуураараа нүүрээ арчин будгаа нялж, нулимсандаа хахаж цацан зогсоно. Айх гайхах зэрэгцсэн Нина түүнийг тайтгаруулах санаатай,

–Боль л доо, одоо яах вэ дээ. Софья Александровнагаар дайрч юу болсныг мэдэж авья гэв.

Нэг эмгэн хажуугаар нь өнгөрч явснаа Варяг харж өрөвдөн толгой сэгсрээд,

–Хөөрхий охидууд цэргийн багачуулынхаа хойноос уйлцгааж байна хэмээв.

Хоёрдугаар хэсэг

1

Цөллөгийн түрүүчийн хүмүүсийн тайга дундуур гаргасан Ангара орох хуучин зам Тайшетээс эхэлнэ. Шинэ нь Канскт, төмөр зам дуусаж явган явах ээлж эхэлдэг учраас тэндээс эхэлнэ.

Модоор явган зам тавьсан, цэцэрлэг байхгүй, талын хоттой төстэй нам гүм хот. Дахиад л хөх тэнгэр толгой дээр гэрэлтэж дотор мансуурам амьдралын үнэр ханхална. Шоронгийн өрөө, Дьяков, салхинд гарах бяцхан хороо, нойрмог харцаар харуулдаж байдаг винтов буутай харуул энэ тэр эргэлтгүй алга болжээ. Энэ бүхнийг нэгэнт болсон явдал гэхэд нэг л үнэмшмээргүй санагдана. Чи гэдэг хүн чемоданаа чирэн гудамжаар чөлөөтэй явж байх юм, хажууд чинь Борис Соловейчик Канскт үлдэж чадаагүйдээ харамсан үглэж явна, ингэхлээр энд байхад бусдын адил л хүн гэлтэй.

–Над шиг нарийн мэргэжилтэй хүнийг тосгонд явуулна гэнэ ээ?! Ингэлээ гээд улсад ашиг байна уу? хэмээн Соловейчик үглэнэ.

Үүдэндээ саравчтай бяцхан байшин бол шуудан, хадгаламжийн касс яг тэнд нь байна. Гэрийн даашинзтай, гар хуруу нь бэх, цавуу болчихсон бүсгүйчүүл Соловейчикийг захидлаа өөрөө хүлээн авдаг, Москвагаас ирсэн яриа хөөрөөтэй, царайлаг хүн гэж мэднэ.

“Бие сайн Канскийн тойрог Богучаны гацаа өөрөө хүлээн авах гэж бичээрэй үнсье Саша” хэмээн ээждээ анхныхаа цахилгааныг явуулав.

Бүсгүй үгийг нь тоолж, хэдийг төлөхийг хэлснээ тасалбар бичиж өгөөд мөнгөө хурааж авлаа. Хөгжилтэй сайхан бүсгүйчүүлтэй газар юм...

Соловейчикийн байгаа айлын эзэгтэй гэж нэг номой царайтай залуухан туранхай хүүхэн ширээ заслаа. Юунаас болж энэ эмэгтэй Борисыг гэртээ оруулаа вэ? Яваад өгөхлөөрөө л түүнийг таг мартчихна даа. Сэтгэлд нь таацаа юм болов уу? Цөллөгийн хүнийг гэж өрөвдөө юм уу? Нийслэлийнхээ дээгүүр занг орхиогүй Борис тэр хүүхний дэргэд арчаагүй хөөрхий харагдах ажээ.

Саша чемоданаасаа ганц лааз шпрот гаргалаа. Ээжийнх нь зэхэж өгсөн юмнаас үлдсэн юм ердөө л тэр.

Борис шил архи задлав. Тэрээр хувьдаа хундагатай төдийгүй амны алчууртай байх нь энэ газар хүртэл хүн шиг аж төрөхсөн гэдэг бололтой. Юм бүхэн ердийн амьдралд байдагтай л адилхан байна. Гагцхүү өөрснийгөө хэн билээ гэдгийг бодвоос зүрхэшмээр хачин аймшигтай санагдана. Гэхдээ бас ч гэж тийм ч их аймшигтай биш юм аа. Саша ганцхан хундага уугаад л толгой нь эргээд явчихав.

–Шоронгийн дараа тэгдэг юм, аяндаа дасна гэж Борис өгүүлээд, –Ангарад бол спирт л ууж байх болно шүү дээ, тийш нь архи зөөснөөс спирт зөөсөн нь хямд байдаг юм, зургаан зуун километр газар мориор зөөнө. Яаж ийгээд амьдарна аа. Богучаны бол том гацаа, би

мэргэжлийнхээ ажлыг олно, та ч гэсэн инженер болоход ганцхан хуруу дутуу хүн болохоор тэнд трактор, үрлэгч, цайруулагч энэ тэр бий гэв.

–Би тракторыг мэдэхгүй, үрлэгч, цайруулагчийг ч мэдэхгүй.

–Ам хөдөлбө гэвэл дор нь мэдэх болно доо. Дээхэн үед сэхээтэн залуус хилийн чанад руу явцгаадаг байсан, та бид хоёр бол цагаан баавгай руу ирцгээлээ. Цагаан баавгайн нутагт бор баавгай байснаас Москвад “цагаан баавгай” байсан нь дээр. Одоо тэгэхлээр яах вэ? Уйлах уу, майлах уу? Би уул нь Улсын төлөвлөгөөний хорооны дарга болох санаатай байсан юм, үгүй ээ, дарга биш, намын гишүүн биш болохоор орлогч дарга л таарна. Би бол жинхэнэ ажлын хүн, тэрэгний морь, хэнд ч тээр болдоггүй, харин ч хэн болгонд хэрэгтэй байсан хүн. Гэтэл миний замын урдуур хэлний зүйн цэг тэмдэг дайраад ороод ирсэн, намайг тодорхойлох цэг зогсоосон юм. Цөллөгт байгаа нэг ч хүн үнэнээ хэлэхгүй гэдгийг та мэдэх хэрэгтэй. Хэрэг хийчихээд сууж байгаа хүн ямар ч гэмгүй хэрнээ сууж байгаа юм шиг царай гаргана, ямар ч гэм хийгээгүй хүн ямар нэг хэрэг хийчихээд сууж байгаа дүр гаргана. Харин надад бол та үнэмшиж болно. Ийм юм болсон юм. Манай байгууллагад “Техник үйлдвэрлэлийн шинэчлэлтийн үед бүхнийг шийдэх нь. Сталин” гэсэн уриа хадаатай байх л даа. Та тийм уриаг мэдэх үү? Мэдэх юм байж. Сайн байна. Би тэр уриаг нэг хөөрхөн хүүхний дэргэд уншсан юм. Гэтэл тэр хүүхэн миний цэг тэмдэг мэддэггүйг илчилдэг байгаа даа. Анхааралтай сонсоорой. Би нөгөө уриаг “Техник: үйлдвэрлэлийн шинэчлэлтийн үед бүхнийг шийдэх нь Сталин” гэж унших шиг тэр хүүхэнд санагджээ. Нөгөөх чинь боловсролтой амьтан байсан болохоор миний харанхуй бүдүүлгийг тэвчин өнгөрөөж чадалгүй тийнхүү гутарсан тухайгаа зохих хүнд хэлж л дээ. Би хэзээнээсээ дуудлага муутай юм чинь за яахав нэг сайхан донго авна биз л гэж бодлоо. Гэтэл хувьсгалын эсэргүү ухуулга, суртал нэвтрүүлэг хийсэн хэргээр тавин наймдугаар зүйлийн арвыг авдаг байгаа даа. Бас ч гэж гайгүй шүү, зөв бичгийн дүрэм судлахад надад гурван жил хангалттай гэж үзсэн. Энд муугүй ажилд орсон, “Ангийн үс бэлтгэх газрын” эдийн засагч. Намайг ирснээс хойш бэлтгэсэн ангийн үсний хэмжээ буураагүй гэдэгт та эргэлзэхгүй байж болно. Гэвч цэг тэмдгийн дүрмийг эзэмшихэд Канск хот дэндүү өөгдөнө гэж үзсэн бололтой. Тэгээд түрүүчийн хэсэгтэй, өөрөөр хэлбэл тантай хамт би Ангара руу явна. Богучанын “Ангийн үс бэлтгэх газарт” тоо буртгэгчийн албанд орохсон гэж мөрөөдөж байна. Саша минь, та бид хоёрын хөөцөлдөх зүйл бол Москвагийн аль нэг пэдгэр бандид өчүүхэн зүйл мэт санагдана. Харин та бид хоёрын хувьд бол тэр чинь эндээс тэсэж гарна гэсэн үг.

Борисын зөв байж магадгүй. Гэвч Саша өөртөө өөр зам сонгож авчээ. Тэрээр яв гэсэн газар луу нь явж, бай гэсэн газар нь байх болно. Ямар нэг юм хөөцөлдөнө гэдэг бол Дьяков мэтийн хүний өөрийг нь энд байлгах эрхийг хүлээн зөвшөөрсөн хэрэг болно. Гэтэл түүнд тийм эрх байхгүй гэж үзэж байгаа билээ.

–Та Москвагийн хаахна аж төрж байв? гэж Борис асуув.

–Арбатад.

–Бас муугүй шуу. Би Петровкад, мөсөн гулгууртай байшинд суудаг байсан, мэдэх үү?

–Мэднэ.

–Миний идэр нас “Эрмитаж” цэцэрлэгт өнгөрсөн гэдгийг та аль хэдийн гадарлачих шиг боллоо. Би тэнд хэдэн үдшийг тун аятайхан өнгөрүүлсэн шүү. Гэвч миний цадик өвөөгийн ярьдгаар... Цадик гэж юу гэж байгааг мэдэх үү? Мэдэхгүй гэнэ ээ. Цадик гэдэг бол гэгээнтэн, мэргэн хоёрын завсрын юм гэх үү дээ. Тэгэхлээр миний цадик өвөө тиймэрхүү үед гинуг! гэдэг юм. “Гинуг” гэж юу болохыг та бас мэдэхгүй биз дээ? “Гинуг” гэж “гүйцлээ” “болох нь тэр” гэсэн уг... Тэгээд би одоо элдвийг дурсан гинуг, уйлж хайлж гинуг! гэж хэлж байна.

Өглөө нь тэр хоёрыг сэрээгүй байхад эзэгтэй нь ажилдаа явжээ. өглөөний хоолыг пийшин дотор төмөр хаалтны цаана тавьсан байв.

–Жирийн хүүхний аугаа их давуу тал гэж энэ дээ, би юунаас болж авгайгаасаа салсан бэ? хэмээн Борис асуугаад,

–Эрт босож халуун хоол хийж өгөхгүй л гээд байсан юм даа. Тэгээд юу болов? Хар хүнээ л алдсан. Гэхдээ тэртэй тэргүй л алдах байж л дээ. За ингээд “Ангийн үс бэлтгэх газрын” мундаг трест рүү чөлөөгөө ёсоор болгохоор явцгаая. Амралтын тэтгэвэр авна гэж би горьдохгүй байна, гэхдээ Богучаныд авч очих албан бичиг тэндээс ямар ч байсан салгана. Та сахлаа хусах уу? гэв.

–Үгүй ээ.

–Саша, та аан гэж бай, танд сахлын хэрэг юу байх вэ, хусаж орхи. Одоо ингээд гадагшаа гарахаар энд ямархан охид байдгийг та үзнэ дээ.

Саша эндхийн охидыг хэдийн харсан билээ. Бие хаа сайтай, хөл гар чанга, халиун үстэй сибирь бүсгүйчүүл үнэхээр нүд булаам сайхан байсан. Тэрээр Сибирыг суухад даяанч шиг байх мэт санагдаж, гурван жилийг талаар өнгөрөөх ёсгүй, франц, англи хэл үзэж, улс төрийн эдийн засгийн ухаан судална гэж боджээ. Гэтэл одоо эргэлзэж эхлэв. Зөвхөн энэ мэтээр ч хоног төөрүүлэхгүй бололтой.

–Ямар ч будаг шунх байхгүй, бүх юм байгалиас заяасан янзаараа шүү дээ. Гурав хоногийн дараа явах юм чинь та бид хоёр зугаалж амжина. Гэхдээ хонгор минь, ийм сахалтай байх юм бол гэртээ байсан нь шулуун гэж Борис өгүүлэв.

–Энд сахлаа хусах дур алга.

–Та туршлагатай хүний үгэнд ор. Та бол цөллөгт ирээд анхныхаа өдөр болж байна, би бол гурав дахь сараа авч байна. Та амьдралаа сулрах хүртлээ хойшлуулах юм бол нэгэнт өнгөрсөн хүн болно гэсэн үг. Өөрийгөө хадгалж үлдэх цорын ганцхан арга бий, юу ч болоогүй юм шиг л аж төрөх хэрэгтэй. Тэгвэл л эндээс мултрах боломж гарна.

Ханы нь хээтэй цаас гандаж таазных нь дусаалд шарлантсан цагаан цаас энд тэндгүй хавагнан хөндийрсөн намхан өрөө. Хажуугийн өрөөнд хүүхэд уйлна. Гэхдээ үнэртэй ус, оо энгэсэг ханхална. Үсчний газар байдаг ердийн хоёр түшлэгтэй сандалтай, үсчингүүд нь савхин гуталтай ч гэсэн цагаан халаадтай, Москвагийн үсчингүүдийн адил тахимдуу ширүүн царайтай ажээ.

Хагар хагар туссан булингартай толинд Сашагийн тун сая танасан мэт тэгшхэн долгиотой хар сахал бүхий өлөн цагаан царай тусав.

–Бүүр хусчих юм уу?

Үсчин бодол болсон мэт хайчаа агаарт нэгэнтээ хий чадхийлгэснээ Сашагийн сахлыг эрсхэн барьж аваад тас хяргахад хайчилсан үс хуучин нөмрөг дээр уналаа. Үсний машин дуржигнан нуугиж савангийн бүлээн хөөс хацар дулаацуулан байхуйд Саша Арбатын үсчин, тэндхийн үнэр, тэндхийн хурц гэрэл, баярын өмнө хөл үймээнтэй байдаг энэ тэрийг өөрийг эрхгүй дурсан санах.

–Энэ чинь та юу, биш үү? хэмээн Соловейчик гар алдлан гайхаж,

–Та ч одоо бидэндээ хүдэр сайхан эр болчихлоо шүү дээ гэв.

Тэд дахиад гудамжаар явцгаахад Саша ч охид руу нүүр бардам харж цаадуул нь ч мань хүн рүү хараа шиднэ.

–Биднийг энд үлдээдэгсэн бол эндхийн хүмүүсийн үүлдэр угсааг сайжруулахсан даа. Канскт цөллөгийн хүмүүс дүүрэн байгаа юм чинь хоёрхон хүнээр нэмэгдэхэд яах вэ дээ гэж Борис өгүүлэв.

–Ямар хүнийг үлдээдэг юм бэ?

–“Сэн”... Үлдээсэн юм бэ гэж ярина шүү. Өвчтэй, олон хүүхэдтэй, их өндөр настай, бие ядмаг энэ тэрийг нь... За нэг нөхөр явж байна, түүн рүү битгий ширтчихээрэй, меньшевик хүн, тэдний удирдагчдын нэг нь.

Пальто, эсгий малгайтай, урт буурал үс нь захаа давсан, таяг тулсан нэг өвгөн тэдний өөдөөс ирж явав. Соловейчик мэхэсхийн мэндчилэв. Өвгөн мөн хариу мэхэсхийхдээ танихгүй хүнтэй мэндэлж байгаа мэт итгэл муутайхан дохив. Харин дараа нь түүнийг танимагц малгайгаа өргөсхийн ялдамхан инээмсэглэв.

Борис ийнхүү өвгөн тоож хүндэлсэнд дотроо бахархан,

–Тэмдэглүүлэх гэж явж байна. Таван, хорины өдөр хоёр тэмдэглүүлдэг юм гэж өгүүлээд,

–Өвгөнийг хэдтэй гэж та бодож байна? гэж өгүүлэв.

–Жартай.

–Далан хоёртой байвал яах вэ? Энд та меньшевикүүд, эсерүүд, анархистууд, троцкистууд, үндсэрхэг нугалаатнууд гээд янз бүрийн хүнтэй тааралдана. Хуучин нэр цуутай явсан хүмүүс ч бий.

Саша Зөвлөлт Холбоот Улсад меньшевик, эсерүүд одоо хүртэл байдаг гэж хэзээ ч бодоогүй билээ. Харин троцкистуудын явдал бол өөрийнх нь нүдэн дээр болсон хэрэг. Тэр

түрүүчийнхэн юу ч вэ дээ? Үнэхээр ойлгохгүй байна гэж үү? Ямар нэгэн юманд горьдож найдаж байх нь уу... Тэгээд өөрснийхөө хэргийг үргэлжлүүлж байгаа юм уу?.. Үргэлжлүүлж байгаа юм юу ч байхгүй ч юм билүү?

“Ангийн үс бэлтгэх газрын” гуанзан гэж нэг байшингийн намхан газар давхарт байрласан бүтээлэггүй дөрвөлжин ширээтэй гуанзанд мань хоёр хоол идэв. Хоол олгодог өргөн цонхны цаана зуухан дээр уур савсан гурван том цагаан сав, дэргэд нь халбага барьсан улаан хацартай тогооч авгай зогсох нь гал тогоо ажээ.

—Энэ бол ажилтан нартаа зориулсан хаалттай гуанз гэж Борис тайлбарлаад,

—Гэхдээ байгууллагын кассанд бэлэн мөнгө хэрэгтэй учраас гаднын хүн орохыг тоодоггүй юм. Өөрийн тэжээлийн цэгтэй, гахай, молтогчин туулай, шувуу үржүүлнэ. Цөллөгийнхний тэн хагас нь энд хоног төөрүүлж байгаа. Аль нэг хүн өөрийг нь чухам энд ажилд оруулсан хүн гэж намайг хэлбэл түүнд үнэмшиж болно гэж ярив.

Тогооч авгай Борисыг харангуутаа халбагаа тавьж гараа хормогчиндоо арчаад гал тогооноосоо гарч ирэв.

—За Борис Савельевич минь, өнөөдөр хүрэн манжингийн шөл, нухсан төмстэй нарийн махан хуурга байна, жаахан хүлээвэл төмсийг нь шараад өгсөн ч болно гээд авгай түүн руу хазайж, — үнээний ганц шил сүү бий гэв.

—Шарчих, шарчих гэж Борис тун додигор өгүүлэв.

—Борис Савельевич, та явчих гэж байгаа юм уу?

—Тэгж байна. Хивэг авчирсан уу? гээд Борис хөмсөг зангидав.

—Дөрвөн шуудайг авчирсан. Маргааш бас авчирна гэцгээсэн. Хоолны үнийг дахиад л будлиулчихжээ, гуляшийг найман копейкоор дутуу гүйлгэж байгаа. Бас пийшинчтэй хэл амаа ололцоогүй гэнэ, пийшингээс утаа савсаж нүд хорсгоод болдоггүй ээ.

Тэрээр Бористой ярихдаа энэ хүний үед бүх ажил жин тан байсан, ингээд явчихлаар нь элдэв бүтэлгүй явдал эхэлнэ гэж байгаа юм шиг байв. Борис ч гэсэн нээрэн л тэгэх ёстой доо гэж байгаа мэт царайлж тэрээр одоо эндхийн хэн ч биш болсон гэсэн урьдын адил хүндлэл үзүүлж байгааг үзэхэд өөрт нь таатай байгаа нь андашгүй.

—Би бүр дэмий яриад хадуураад явчихлаа, та чинь хоол идэх гэж яваа шүү дээ хэмээн тогооч авгай санаа нь зовчихов.

—Надаас өмнө энэ гуанзанд таван хүн ажиллаж байсан юм. Одоо гал тогооны ажилчин, энэ авгай хоёр л үлдээд байгаа юм. Энэ тогооч чинь кассчин, зөөгч, дарга гурвыг давхар хийнэ. Гэхдээ энэ гуанз бол юу ч биш. Би энд хоёр сарын хугацаанд юу хийснээ танд ярьж өгч болохсон. Гэвч одоо энэ бол хэнд ч сонин биш. Манайд юугаар ч сольшгүй хүн гэж байхгүй, өнөөдөр би, маргааш чи шүү дээ. Гэхдээ сайн бодоод үзэх юм бол энэ үг утга учиргүй зүйл.

Номын санд Пушкины зохиол байхгүй байлаа гэхэд би Толстойг оронд нь авч болно, гэтэл тэр чинь Пушкин биш, Толстой л шүү дээ. Миний албан тушаалд өөр хүн томилсон, гэтэл тэр чинь шал өөр Пушкин гэсэн үг гэж Борис ярив.

Гуанзанд нэгэн жижигхэн хүн хулчгархан орж ирэв. Залуухан хэрнээ бөгтийчихөөд, харах царайнаасаа доожоо муутай, сахлаа ч хусаагүй, малгайнх нь саравч хугарчихсан, товч нь дутуу унжгар ноорсон хүрмээ балиар цамцан дээр угласан, шаахай нь ялбийчихсэн, эв хавгүй хөвөнтэй өмд нь хүлхийж халхайн шулхаганых нь сагалдарга сул унжиж байх ажээ.

–Өө Игорь! хэмээн Борис түүнд дуу өгч,

–За нааш ир, нааш ир! гэв.

Игорь ичингүйрэн инээмсэглэсээр дөхөж ирэв. Түүний цэнхэр нүд, нарийхан цагаан хүзүүг Саша олж харлаа.

–Малгайгаа ав, гуанз шүү дээ гэж Борис хэлэв. Игорь малгайгаа авч базлахад ойрд засаагүй хиртэй хүрэн үс нь арван зүгтээ арзайжээ.

–Ажил явдал сайн уу? гэж Борис асуув.

–Зүгээр, сайн гээд Игорь цөөхөн шүдээ архайлган инээв.

–Сайн гэдэг чинь сайн. Гэтэл зүгээр гэдэг чинь зүгээр. Дахиад л хөөгдчихөө юу?

–Үгүй ээ, яаж байна? Шинжилгээний ангийнхантай явуулахгүй байна.

Энэ хүний сэхээтнийх гэлтэй аятайхан дуунд нэгэн онцлог аяс байвч чухам юу вэ гэдгийг Саша ухаарсангүй. Тэр дуу сэтгэлд тогтож байна.

–Игорь хөрөнгө данслах конторт ажиллаж байсан юм. Байшин барилга хэмжиж, байршлынх нь зургийг зураад л тоос шороогүй бас тэгээд хийснээрээ авдаг, цалин сайн авч болох ажил хэмээн Борис тайлбарлаад,

–Гэтэл энэ эр залхуурна, зурсан зургаа тос болгочихоод аваад ирнэ. Игорь, чамд чинь тос бийсэн билүү? Байдаг юм бол зурган дээр биш талхан дээр түрхэх хэрэгтэй. Чамайг шинжилгээний ангийнхантай явуулахгүй байна гэдэг чинь чи залж байна л даа! Тэдний тэн хагас нь Канскт үлдэж байгаа, чи хэрвээ хүн шиг хүн байсан бол бас үлдэж болох байсан шүү дээ.

Игорь малгайгаа базлан гэмшин мушилзана.

–За яахав! хэмээн Борис сургаалаа дуусгаж,

–Юм идмээр байна уу? Мэдээж идмээр байна! Мөнгө байна уу? Мэдээж байхгүй! гэв.

–Би хэдхэн хоногийн дараа найман зургийнхаа мөнгийг авна.

–Чи тэр найман зураг гэж хоёр сар ярьж байгааг чинь би мэдэж байна...

Тэгснээ Борис,

–Марья Дмитриевна, Игорийг хооллоод орхиоч, би мөнгийг нь төлнө гэж чанга хэлэв.

Тогооч авгай хөмсөг зангидан таваг шөл, хэрчим талх цонхоор зүглүүлэв. Игорь малгайгаа халаас руугаа чихэж, талхаа сугандаа хавчуулаад, тавагтай шөлөө хоёр гардан эв хавгүй барьсаар тэртээ захын ширээ рүү сажлав.

–Энэ юун хүн бэ? гэж Саша асуув.

–Энэ бол нүдтэй эр, шаггүй этгээд шүү. Яруу найрагч. Цагаачилж одсон цагаантны хүү. Парист байхдаа комсомолын яггүй зүтгэлтэн болж ЗСБНХУ-д буцаж ирсэн. Гэтэл харахгүй юу, ингээд Канскт ирчихсэн байж байгаа юм.

–Яасан гэж тэр вэ?

–Та гэнэн юм асууж байна. Бид хуйвалдааныг үүсэл төдий байхад нь устгаж байгаа шүү дээ. Би нэг буруу явган шог ярьсан байя гэж саная, тэгвэл би тодорхой чиглэлтэй юм бодож байгаа гэсэн үг, тэгээд таатай нөхцөл бүрдвэл зөвлөлтийн эсрэг үйл ажиллагаа явуулж чадна гэсэн үг. Та буруу ханын сонин гаргасан, тэгэхлээр маргааш нь нууц сэтгүүл, нөгөөдөр нь ухуулах хуудас хэвлэнэ. Ингэхлээр тун хүнлэг байгаа биз дээ? Ханын сонин гаргасан гэж таныг гурван жилээр заасан, харин ухуулах хуудас гаргасан бол буудан алах байсан, ингээд бодоход таны амь насыг хямгадсан байна. Игорь Парист өсөж бойжсон, цагаачны хүү, өөрөөр хэлбэл хувьсгалаас хохирсон хүний хүү, тийм учраас яаж ч мэдэх хүн гэж үзэж болно. Тэгэхлээр тэр хүний өөрийнх нь ашиг тусыг бодож тусгаарлах хэрэгтэй.

Игорь булангийн ширээнд суугаад шөлөө бушуухан идэж байв.

Борис түүнийг хараад,

–Жирийн хүн идэж уусныхаа дараа юмаа өөрөө эмхэлдэг учраас хаа ч байсан хүн чигээрээ байх юм. Харин язгууртан хүн бол хүнээр арчуулж цэвэрлүүлж сурсан байдаг болохоор тийм арчигч байхгүй бол мал болж хувирна. Энэ ноёнтон ажил хийх дургүй, гуанзны хоолны шавхруу долоогоод, байгаа айлаасаа байнга хөөгдөж яваа арчаагүй амьтан! Мөнгө зээлээгүй хүн ч байхгүй, буцааж өгсөн хүн ч байхгүй. Цөллөгт яваа улсын дунд ёроолгүй баян хүн байхгүй гэдгийг та ойлгож байгаа. Гэхдээ цөллөгийнхөн өөрснөө энүүний хойноос үзээгүй юмаа үзэж үхэр цам харайх мэт гүйлдэж байгаад муу зан сургачихсан юм. Яруу найрагч гэдэг чинь тоглоом уу даа! Парисаас ирснийг хэлэх үү! Парис! Франц! Шадар гурван цэрэг! Эцэг-Дюма! Хүү-Дюма!.. Харин тэр ухаан жолоогүй дагаж гүйдэг улсаас хэн нь ч ам хөдөлгөх юм өгдөггүй, ганц би өгдөг болохоор мань хүн надаас л айдаг юм. Намайг хүний үнэргүй барлаг гэж дотроо үзэн ядаж байгаа боловч миний зэмлэлийг тэвчихээс өөр аргагүй байгаа. Харин намайг Ангара руу яваад өгөхлөөр надгүйгээр энэ өлбөрч үхнэ! Гэхдээ хамгийн сонирхолтой юм нь өөр зүйл бий. Өөрийнхөө Дульсинеяг хүлээж байна. Хэрвээ тэр нь хүрээд ирвэл та хэзээ ч үзээгүй, энэ яваа насандаа үзээгүй юмаа үзэх юм байгаа юм. Өө нөгөөдөх нь ч хүрээд

ирлээ гэв.

Даамай янзын цэвэрхэн том амтай сүрлэг дагина гэлтэй гуч эргэм насны дуу алдам сайхан хүүхэн гуанзанд орж ирлээ. Тэрээр тайван харцаар гуанзыг эргүүлдэн харж Борис руу хээвнэг дохихуйд цаадах нь ёс төрийг бодож өөдөөс нь толгой мэхэсхийв. Тэгснээ хүүхэн тэртээ буланд тавган дээрээ тонгойн суугаа Игорийг олж үзэв.

–Ийм хүний оронцогт ийм хүүхэн байх гэж хэмээн Борис халаглан гүвтнэв.

–Юун хүүхэн бэ?

–Цөлөгдсөн нөхрөө хайж Ленинградаас ирсэн юм, тэгээд энэ тулманд дурлачихдаг байгаа даа. Энэ хоёр өдөр болгон энд ирж цаадах нь түүнд шүлэг уншиж өгч, мань хүүхэн Дориан Грейн хөргийг харсан мэт өөдөөс нь хараад суучихдаг юм.

Хүүхэн Игорььт нэг юм ярьж, нөгөөдөх нь хи-хи хөхрөн, ширээн дээрээс талхны үртсийг түүж ам руугаа хаялна. Өчүүхэн ч дур татах юм байхгүй арчаагүй уймраа амьтан. Дараа нь хүүхэн босож хоол өгөх цонх руу очиход тогооч авгай аанай л дурамжхан янзтай таваг шөл түүнд бариуллаа. Игорьь туслах санаатай хөдлөх аядсан боловч боссонгүй. Хүүхэн талх, халбага авахаар буцахад мань эр түүний араас бас зүглэсэн боловч буцаад суучихав.

Хүүхнийг шөлөө идэж байх зуур мань хүн нэг юм ярина. Царай нь залуухан хэрнээ үрчийж үнгэлджээ. Хүүхэн түүнийг сонсох хооронд хаа нэг дохино. Дараа нь хоёрдугаар хоолоо авчраад хагасыг нь өөртөө шөлнийхөө тавганд хийж аваад үлдсэнийг нь Игорььт дөхүүлж өгөв.

–Багалзуур! хэмээн Борис шаралхан дургүйцэж,

–Энэ муу хайртай хүүхнийхээ хоолноос булааж, өглөөнөөс орой хүртэл идсэн ч чадна. Хүмүүс үүнээс дор нөхцөл байдалд хүн чигээрээ л байдаг. Гэтэл энэ муу Парисын гудамжны бэлтрэг хэн гээч болж вэ? Зүгээр нэг хээгүй амьтан биш шүү, тэгж бодохын ч хэрэггүй. Огт биш! Ичгүүр сонжуургүй увайгүй амьтан, юмыг нь мулзалж байгаа хэрнээ дотроо тэр хүнийг дооглож байгаа. Хувалз! Өөрийгөө л хайрлана, гэтэл өөрийгөө хайрлана гэдэг чинь бусдыг үл хайрлана гэсэн үг, миний цадик өвөө хүртэл тэгж ярьдаг байсан юм. ЗСБНХУ-д ирж гэнэ! Зөвлөлт Холбоот Улсад их гийгүүлж өгч байна гэж бодоо вий, гэтэл хүрээд ирсэн чинь ажиллах хэрэгтэй нь мэдэгдсэн хэрэг. Тэгээд ажиллах дургүй болохоор нь нийгэм өөрийнхөө дундаас шахаж гаргаад таягдан хаяж л дээ.

Саша инээмсэглэн,

–Түүнийг буцаагаад Парис руу нь таягдчихсан бол илүү зөв байжээ гэж өгүүлэв.

Тэр хооронд хүүхэн хоолоо идэж гүйцээд тавгаа хажуу тийш нь түлхэж, ширээ тохойлдон эрүүгээ тулаад, Игорийг ширтээд суучихжээ.

Гэтэл цаадах нь ихэмсэг төрхийг олж, сандлаа налж гэдийгээд толгойгоо духайлган бувтнаж эхлэх нь тэр...

Тэрээр дуугаа өргөхгүй нэгэн хэмээр шүлэг унших бөгөөд загалмайтнууд, Иерусалимын хэрэм, шар элс, төөнөсөн нар, хэзээ ч эргэж ирэхгүй баатруудаа хүлээж буй хүүхнүүд гэхчлэнгийн салангид үгс л Сашад сонсдоно.

–Танд ямар санагдаж байна? Зоригт баатрууд, үзэсгэлэн гуа хатагтай нар. Канскт, “Ангийн үс бэлтгэх газрын” гуанзанд! Ямар вэ дээ? гэж Борис шивэгнэн асуув.

Үнэхээр инээдэмтэй юм. Гэвч энэ нэгэн байдал, Игорийн хувилсан царай, сайхан хүүхний гүн бодолд автсан харц энэ тэрд ямар нэгэн ид шидийн юм байх шиг санагдана.

Саша нэгэн зуур оволзож ирсэн дургүйцлээ дарлаа. Энэ дургүйцэл бол эс тэвчих хүмүүжлээр хүмүүжсэний илрэл билээ. Тэгээд мань хүн Борист,

–Нигүүлсэнгүй байцгаая даа гэж хэлэв.

Москваг шинэчлэн байгуулах Ерөнхий төлөвлөгөөг хэлэлцэх зөвлөлгөөн дуусах тийшээ хандаж байхад Сталин тэнд иржээ. Тэрээр Каганович нээлтийн үгэндээ юу хэлэхийг мэдэж байсны гадна Булганины илтгэлийг уншсан байжээ. Шинэчлэн байгуулалтын холбогдолтой бүх санал бодлыг Сталинд хэдийнээс нааш илтгэж, Улс төрийн Товчоогоор хоёр ч удаа хэлэлцсэн болохоор мань хүн өөрийнхөө үзэл бодлыг нэгэнт боловсруулчихсан юм байж. Энэхүү үзэл бодол нь Москвагийн шинэчлэн байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөнд бүрэн тусжээ. Ерөнхий төлөвлөгөө гэдэг нь ерөөсөө л түүний үзэл бодол аж.

Түүнийг тэргүүлэгчдийн байранд гарч ирэхэд бүх хүн босож алга нирхийн ижил дасал болсон янзаар улам хүч аван нижигнэлээ. Сталин мэндчилж буйн дохио болгон гар өргөөд тэр даруй суусан нь бусад хүнийг мөн суу гэсэн урилга байжээ.

Индэр дээр нэг хүн үгээ дуусгаж байв. Сталин түүнийг анхааралтай сонсож байгаа дүр гаргах зуур Гори хотоос арваад километрийн зайтай оршдог Атени хэмээх бяцхан гацааны хуучин сүмүүдийн балгасыг цаасан дээр зурж суув. Тэр гацаанд түүний эцэг гуталчин Жугашвилийн захиалагчид аж төрдөг байсан юм. Эцэг нь биелүүлсэн захиалгаа тийшээ авч очдог, заримдаа тэнд нэг хоёр өнжиж гутал тахалдаг билээ.

Тэрээр бяцхан Иосиф хүүгээ дагуулж явах нь олонтой. Тэр хоёр Горигоос өглөө эртлэн гарч Тана голын эргийг барин усан үзмийн цэцэрлэг дагаж, Атенийн хуучин сүмийн балгас хүртэл явна. Энэ бяцхан гацааны билүү арван балгастай, тэдгээрийн дотор домог ярианаас үзэхүл аль долдугаар зуунд барьсан гэх пөмбөгөр оройтой Сионын хийдийн сүм бий. Сүмийн нүүрэн талд тэр үеийн түүхт хүмүүсийн баримал дүр, дугана дотор талын хананд мөн түүхт хүмүүсийн усан будгийн хөрөг зураг хадгалагдан үлджээ.

Хамгийн дорвитой хөшөө дурсгал бол уран барилгын дурсгал, яагаад гэвэл хийсэн эдийнх нь яс бөх, гадаа ил байдаг, өргөн олон түмэн байгаа байдлаар нь эсвэл уран зургаар юм уу гэрэл зургаар үзэх боломжтой. Ленин монументаль суртал ухуулгыг шаардаж байсан болохоор уран баримлын ач холбогдлыг ойлгож байсан хэрэг. Гэхдээ Ленин бол түүнийг олон түмний ухамсарт шинэ шинэ түүхт хүмүүсийг шингээн нэвтрүүлэх арга гэж ойлгож байсан. Гэтэл монументаль суртал нэвтрүүлгийн жинхэнэ зорилго бол эрин үеийг мөнхлөх явдал. Тэр үед байгуулсан тавин хөшөө дурсгалаас хичнээн үлдээд байна вэ? Нэг үү? Хоёр уу?

ТҮҮНИЙ эрин үеийн дурсгал нь Москва, ӨӨРИЙНХ нь цоо шинээр цогцлон байгуулах тэр л хот болох ёстой. Гагцхүү хот л өнө удаан настай. Уран барилгыг төлөв даруу болгох гэсэн хориод оны хандлага алдаа байсан. Эдийн засгийн шинэ бодлогын үеийн өнгөн талаас нь баярхан чамирхдаг аргын эсрэг хувьсгалч эрсхэн төлөв байдлыг сөргүүлэн тавьсан явдал бол хэлбэрдэгч уран барилгачдын сонгомол өвөөс татгалзсанаа хаацайлах арга байсан. Гэтэл сонгомол өвийг л юуны өмнө ашиглах ёстой.

Пётр үүнийг ойлгож байсан учраас Петербургийг чухамхүү сонгомол үлгэр загвараар бариулсан, тэгэхлээр Ленинградыг уран барилгынх нь талаас авч үзэх юм бол хот аргагүй мөн. Гэхдээ энэ бол газардан навтайсан өнгөрөгч эрин зууны хот. Москва бол хойч

үеийнхний нүдэнд тэртээ дээш тэмүүлэн сүндэрлэж байхаар харагдах ёстой. Өндөр барилгыг сонгомол аргатай хослуулбал Москвагийн ирээдүйн дүр зураг болно. Анхных нь өндөр барилга Зөвлөлүүдийн ордон болно. Тийм ордон барих тухай анх Киров хорин хоёр онд Зөвлөлүүдийн Анхдугаар их хурал дээр санал тавьсан. Үүнийг одоо хэн санах вэ дээ? Зөвлөлүүдийн ордныг ӨӨРӨӨ бариулна. Түүнийгээ шинэ Москвагийн уран барилгын төв болгон, шинэ шинэ өргөн чөлөөнүүд гаргаж, метро байгуулж, орчин үеийн орон сууц, албан газрын барилгыг сүндрүүлж, олон шинэ гүүр барьж, голын эргээр засмал тавьж, зочид буудал, сургууль, номын сан, театр, клуб, цэцэрлэг, паркийг өдий төдийгөөр нь байгуулна. Энэ бүхэн ТҮҮНИЙ эрин үеийн сүрт хөшөө дурсгал болох юм.

Сталины ийм бодол түүнийг Атенийн хуучин сүмийн балгаснуудын тухай дурсан санахад хүргэжээ.

Тэр үед, мань хүн хүүхэд байхдаа энэ дутуу нурсан сүм дугануудын эл хуль байдал, олон үеийн нууцыг бишрэн гайхдаг байжээ.

Тэгээд одоо тэргүүлэгчдийн урт ширээний хажууд тэр балгаснуудын дүрсийг цаасан дээр шулуун зураасаар зурж суув. Тэрээр зураг зурж чаддаггүй ч гэсэн чанга гартай болохоор шулуун зураастай дүрсийг шугамгүй хэрнээ аятайхан зурчихна.

–Нөхөр Сталин үг хэлнэ гэж Каганович зарлав.

Хүмүүс дахин босож, аанай л уухай хашгиралдан, алга нижигнүүлэн ташив.

Сталин индэр рүү гарч гар дохин алга ташилтыг зогсоогоод намуухан дуугаар ярьж эхлэв.

–Москваг шинэчлэн байгуулах шаардлага зайлшгүй байгаа тухай энд хүрэлцээтэй ярьсан байна. Надад үүнийг давгах хэрэгцээ алга. Нарийхан, мухар тахир зам, гудамж, эмх замбараагүй баригдсан үхээнц дорой байшин, ажилчдын бүрхэг нэвсгэр хуарантай, балар цагийн унаа хөсөгтэй хуучин модон Москва одоо тус хотын хөдөлмөрчдийн хэрэгцээг яагаад ч хангаж чадахгүй.

Тэрээр түр дуугүй болж чих тавьсан нам гүм байдлыг чагнаваас өчүүхэн төдий ч чимээ алга.

–Зөвлөлт засгийн жилүүдэд хэмээн Сталин түрүүчийнхээсээ аяархан үргэлжлүүлж, – Москвагийн хөдөлмөрчдийн ахуй хангамжийг сайжруулахын тулд бид их юм хийсэн. Байшингийн газар давхарт толгой хоргодож байсан ажилчдыг хуучин мөлжигч ангийн төлөөлөгчдийг шахан нягтруулж байгаад хэвийн орон сууцанд шилжүүлэн орууллаа. Ажилчны хүүхдэд зориулсан олон тооны сургууль, ажилчны клуб, соёлын ордон барилаа. Энэ салбарт бид дорвитой амжилт олсон бөгөөд тэр нь зөвлөлтийн хүмүүсийн сэтгэл зүрхэнд зүй ёсны бахархал төрүүлж байна. Гэхдээ бид ирээдүйн тухай бодох ёстой. Удирдана гэдэг бол урьдчилан харна гэсэн үг. Бид хэдэн арван жилээр урагш харсан төлөвлөгөө зохиох ёстой. Чухам тэр төлөвлөгөө л Москваг шинэчлэн байгуулах Ерөнхий төлөвлөгөө болох юм гэв.

Сталин индрийн цаанаас гарч тайзны урдуур хэд алхав. Танхимд урьдын адил нам гүм хэвээр.

Тэгээд индэр дээр буцаж ирээд цааш нь ярилаа.

–Энэ төлөвлөгөөг биелүүлэх явцад бид хоёр фронт дээр тэмцэх ёстой. Нэг талаас Москваг “том тосгон” чигээр нь үлдээхийн эсрэг, нөгөө талаас их хотын элдэв илүү чамирхлын эсрэг тэмцэх ёстой. Бид өрнөдийн үлгэр загварыг сохроор хуулах ёсгүй. Москва бол социалист хот, социалист улсын нийслэл, чухамхүү энэ байдал л түүний нүүр царайг тодорхойлох ёстой. Энэ бол баячууд нь орд харшид, ажилчид нь шавар пинд аж төрдөг хот биш, энэ бол чухамхүү ажилчдад амьдралын хамгийн сайн, дээд зэргийн тохилог нөхцөл бүрдүүлсэн хот байх ёстой.

Ингэхлээр төлөвлөгөөний нэгдүгээр зорилт бол хотыг аж төрөхөд аль болохоор тохилог байхаар хийх явдал юм. Бид орон сууцны шинэ шинэ тохилог хороолол байгуулах ёстой, болж өгвөл ой модны бүс газарт байгуулах хэрэгтэй. Бид Москва, Жуза голын эрэг дагуух засмал замын хажуугаар гоё тохилог барилгууд барих ёстой. Ингэснээр даруй тавин километр тохижуулсан шинэ гудамжтай болно. Бид хотын гол гудамжнуудын бүх хуучин барилга байшинг нурааж цоо шинээр барилгажуулахын хамт гол замуудыг тавиас далан метр хүртэл өргөсгөх ёстой, тэгснээр мөн хөдөлмөрчдийн эрх ашгийн үүднээс унаа хөсгийн асуудлыг шийдвэрлэнэ.

Сталин дахиад түр дуугүй болов. Тэрээр мэдээжийн юм ярьж буйгаа мэднэ. Гэхдээ энэ бүхнийг МАНЬ ХҮН ярьж байгаа учраас сонсож байгаа хэн боловч цоо шинэ юм шиг хүлээн авч байгааг бас мэдэх билээ.

–Хоёрдугаар зорилгын талаар ярья хэмээн Сталин яриагаа дахин эхлэв. -- Хоёрдугаар зорилт бол дэлхийн анхны социалист улсын нийслэл бол гоё хот байх ёстой явдал юм. Бүр манай төр улс дөнгөж бүрэлдэн тогтож байх үед аугаа их Лениний удирдлагын дор монументаль суртал ухуулгын төлөвлөгөөг боловсруулсан, аугаа их Ленин манай эрин үеийг зуу зуун жилээр дуурсгах хөшөө дурсгал үлдээх юмсан гэж байсан, Лениний энэ гэрээслэлийг бид нандигнан хайрлаж хөгжүүлэх ёстой. Харин тэр үед бид нар ядмаг байсан учраас уран барилгыг даруухан хийхээс өөр аргагүй байлаа. Харамсалтай нь үүнээс болж урлагт хэлбэрдэх арга газар авах зам нээгдсэн, гэтэл хэлбэрдсэн урлагийг олон түмэн ойлгохгүй шүү дээ. Энэ бол бидэнд харш урлаг. Одоо бид овоо бэлтэй, бас тэнхээтэй боллоо, тэгэхлээр юуны өмнө сонгомол өвөөс ашиглах ёстой. Гэхдээ бид Петербургийн хот байгуулагчид шиг сонгомол өвийг сохроор хуулах ёсгүй нь мэдээжийн хэрэг. Сонгомол хэлбэрт бид шинэ, социалист агуулга шингээх ёстой.

Тэрээр дахин нэлээд удаан чимээгүй байснаа цааш нь үргэлжлүүлэв.

–За нөхөд минь, Москва аль чиглэлээр хөгжих ёстой вэ? гэдэг сүүлчийн асуудал байна.

Москваг одоо байгаа чигээр нь, музей дурсгалын газрын маягаар ч гэх юм уу үлдээгээд шинэ Москваг шинэ газар барья гэсэн нэгдүгээр санал байгаа. Энэ саналын эздийг бид хичнээн хүндэлдэг ч гэсэн уг саналыг хүлээн авч чадахгүй юм. Москва бол Оросын түүхэн төв, Москва Оросыг нэгтгэж бүрдүүлсэн, Москвагаас бид зайлсхийж чадахгүй, одоо ч чадахгүй, цаашид ч чадахгүй.

Москвагийн одоогийн төвийг Цэцэрлэгт тойргийн баримжаагаар хөндөлгүй үлдээгээд

түүнийг найман дагуул районоор хүрээлүүлж, орон сууцны найман их цогцолбор байгуулж шинэ Москваг барья гэсэн хоёр дахь санал байна. Энэ бол нэгдүгээр саналын арай хялбарчилсан хувилбар гэдгийг олж харахад төвөггүй байна.

Энэ хоёр санал юунаас үндэслэн гарч байна вэ? Энэ бол юуны өмнө бид Москваг шинэчлэн байгуулж чадна гэдэгт итгэхгүй байгаагаас гарч байгаа юм. Мэдээж, шинэ хот байгуулах нь хялбар л даа. Гэхдээ большевикууд бид нар бол манай Москваг шинэчлэн байгуулах, манай Москваг өөрийнх нь байран дээр үлдээх, Москваг манай орны төв, дэлхийн хувьсгалын төв хэвээр нь үлдээх мэтийн ямар ч хэцүү зорилтыг шийдвэрлэж чадна. Тийм учраас бид Москваг түүний түүхийн явцад бүрэлдэн тогтсон тойроглон цацраглах схемээр нь хөгжүүлэхээр шийдлээ. Орой дээрээ Владимир Ильич Лениний аварга том хөшөөтэй Зөвлөлүүдийн ордон Москвагийн уран барилгынх нь том болно. Зөвлөлүүдийн ордноос Москвагийн гол гол зам зовхислон салбарлаж гарна. Тэр гол замууд нь сайхан тохижуулсан, дор бүрдээ өндөр байшинтай өргөн чөлөөнүүд байх юм. Москва дээшээ, оройн зүг тэмүүлнэ. Дээшээ тэмүүлсэн Москва, социалист санаа туссан сонгомол аргатай хосолбоос сая түүний ирээдүйн дүр төрх гарна. Ирээдүйн Москвагийн дүр төрх тэр.

Сталин аравт арван тав дутуу байхад зөвлөлгөөнөө буцаж ирж өрөөндөө ороход Поскрёбышев,

—Иосиф Виссарионович оо, Шумяцкий киног аваад ирсэн! гэж илтгэв.

—Сайн байна. Шумяцкий харьж болно гэж Сталин өгүүлээд,— Клемент Ефремовичийг ирж кино үз гэж хэл гэв.

Кино үзэх танхим Сталины албан тасалгааны ар талд хамгаалагчийн өрөөний цаана байдаг билээ. Эгнээ бүрдээ найман суудалтай долоон эгнээ сандалтай авсаархан танхим.

Сталин кино үзэхдээ голдуу Улс төрийн Товчооны аль нэг гишүүнтэй үзнэ. Ингэж үзэхдээ нүдний шил зүүгээд хамгийн арын долдугаар эгнээний захын суудалд сууна. Кино аппаратын гэрэл, дуу хоёроос зайлж байгаа нь тэр. Заримдаа өөр зочидтой байвал, гэхдээ тэр нь тун ховор, Сталин нүдний шилээ зүүлгүй хоёр дугаар эгнээний дунд сууна. Түүний нүдний шилтэй байхыг хэн ч үзээгүй, шил зүүсэн байдлаар түүнийг ер зурдаггүй билээ.

Өнөөдөр Сталины тушаасан ёсоор Чарли Чаплины “Их хотын гэрэл” гэдэг киног авчиржээ. Тэрээр энэ киног гурав дахь удаагаа үзэж байгаа нь энэ. Сталин Чаплиныг үзэх дуртай, Чаплин түүнд төрөлх дотно цорын ганц хүн болсон эцгийг нь санагдуулна. Чаплины баатар энэ орчлонд орь ганцаараа байгаа нь Сталинд заримдаа өөртэй нь төстэй санагдана. Гэвч мань хүн энэ бодлоо үнэн байдалд үл нийцнэ хэмээн бушуухан мартахын түүс болно. Чаплин түүнд эцгийг нь, гагцхүү эцгийг нь л санагдуулж байгаа. Хөөрхий Чарли замаар алслан одоодоо эргэж хараад өрөвдөлтэй инээмсэглэнэ... Сталины нулимс асгаран алчуураар нүдээ арчлаа...

Ворошилов түүн рүү хазайж,

—Коба, чи юу болчихов? гэж асуув.

–Энэ миний тухай кино гэж Сталин хэнэггүй өчив.

Гэвч энэ кино бол түүний тухай биш, түүний эцгийн тухай, хувь муутай гуталчин Виссарион Жугашвилийн тухай кино... Эцэг нь мөнгө цаасны мөр хөөж Телави буюу аль нэг өөр газар явахдаа Чаплин шиг ингэж зам дээр эргэж хараад Иосиф хүүдээ гар дохин, өрөвдөм амьтан гунигтай гэгч нь инээмсэглэж байдаг сан.

Тэд нар тэр үед Кулумбегашвили гэдэг бас нэг гуталчныд суудаг байсан. Тэднийх хоёр өрөө байшинтай, нэгэнд нь Кулумбегашвилийнхэн өөрснөө суудаг, нөгөөд нь Жугашвилийнхэн хоргоддог байжээ. Кулумбегашвилийн ажилладаг байшин гуталчны үнэр нэвчсэн, бөгс эргэх зайгүй шахам бөгөөд эцэг нь тэнд байх нь ховор, эхтэй нь байнга түр тар хийлцдэгийг ч хэлэх үү, Кахети рүү явж үүгээр түүгээр хэсүүчлэх нь элбэг. Эх нь цэвэр картвели гүрж цустай, эзэрхэг дураараа хүүхэн байсан, харин эцэг нь Горийн хошуугаар нутагладаг өмнөд осетинхны гаралтай. Өвөг дээдэс нь гүржжиж, Сталины өвөө “Жугаев гэдэг осетин овгийнхоо “ев”-ийг гүржийн “швили” гээр сольсон ажээ.

Эх нь Эгнатошвили гэдэг баян бэлэвсэн эрийнд очиж гэр барааг нь цэвэрлэх, арчиж угаах ажил хийнэ. Сталиныг шашны сургуульд байхад тэр сургуулийнхан чухам тэр бэлэвсэн эрийг Иосифын эцэг, тэгээд л тэр хүн түүнийг энэ дунд сургуульд оруулсан юм шиг ярьцгаадаг байжээ. Бас Иосиф гуталчин Жугашвилийн хүү юм бол Гүрж орноор хэрж тэнэж явахынхаа оронд хүүгээ гуталчныхаа ажил сургаж байлгүй яах вэ дээ гэгцгээнэ.

Цөмөөрөө худлаа ярьж байна, хэнд ч итгэж болохгүй! Эх нь хэдийгээр эцгийг нь байнга зүхэж, түүнээс л болж ийм ядуу явна, хүүхэд бидний хамаг амьдралыг энэ л балласан гэж яншдаг боловч бяцхан Иосиф өөрийнх нь эцэг бол гуталчин Виссарион Жугашвили гэдэг номхон томоотой хүн гэдгийг сайн мэднэ. Ингэж зүхдэг учраас Иосиф эхдээ дургүй билээ.

Эх нь түүнд сайн сайхныг хүсэж байсан нь мэдээж, санваартан болгож бурханд өгөхийг хүсэж байсан юм чинь. Арай амттай хоолноос арай илүү идүүлчих санаатай Эгнатошвилийнд ч гэсэн дагуулж очдог л байсан. Харин Иосиф тэднийд очих дургүй байдаг сан. Тэд нар бол баячуул, мань эр ядуу хүн, өөрт нь таваг будаатай шөл, эрдэнэ шишгэй хэрчим хонины мах гадаа хашаанд гаргаж өгчихөөд өөрснөө байшиндаа дарс уун яриа дэлгэцгээнэ.

Эгнатошвилийнд очихдоо эх нь түүнийг байдгаараа хувцаслахыг хичээнэ. Гэтэл тэгэхийн хэрэг юу билээ? Нэг хэсэг хүн баянаа хувцсаараа үзүүлэх гэдэг байхад нөгөө хэсэг нь ядуугаа хувцсаараа нуух гэж оролддог. Иосиф бол ядуу зүдүүгээсээ ичдэггүй байжээ. Өмд нь ноорчихоо юу? Яадаг юм бэ! Өөр өмд байх ч үгүй. Шаахай нь зан гарчихаа юу? Өөр шаахай байх ч үгүй. Тифлист шашны дунд сургуульд байхдаа мань эр ноорхой байдлаараа бүр бахархдаг байсан. Жинхэнэ эр хүн бол тийм л байх ёстой! Тэрээр одоо ч гэсэн жирийн цэрэг эр шиг хувцасладаг билээ...

Мань хүн ээжийнхээ эрхэнд орохыг хүсээгүй. Эцэгтээ хайртай байсан хэрнээ түүний эрхэнд орохыг бас хүсээгүй учир юун гэвэл эцэгт нь хүн эрхэндээ оруулах эрх зориг байгаагүй. Эх нь эрх зоригтой хүн байсан, Иосиф эхийнхээ зан араншинг удамлаж авсан хэмээн хэн хүнгүй ярьцгаадаг боловч эх нь эрх зоригоо чухамдаа амь зуулгын өл хоол залгуулах ажилд зориулж бүрмөсөн баржээ. Гэтэл эцэг нь хэдэн зоосны төлөө хүний өмнө бөхөлзөж явахыг хүсээгүй, дуулах, тоглоом наадам хийх, нөхөдтэйгөө ширээний ард наргиж суух дуртай хүн байжээ. Яг

тэгээд сууж байхдаа нүдэнд дулаахан, хөгжилтэй, жинхэнэ эр хүн шиг байдаг ажгуу. Гэтэл эхийнх нь дэргэд болохоор биеэ хурааж, амаа барьсан мэт арчаагүй бяцхан амьтан болчихно. Дорой хүмүүн!

Эцэг нь Телавид согтуу улсын зодоонд алагдсан тухай хожим нэг захиа ирсэн. Дахиад л худлаа ярьцгааж байгаа хэрэг. Эцэг нь хэзээ ч зодоон цохион хийж байгаагүй номхон томоотой хүн. Түүнийг хэн, яалаа гэж алах юм бэ? Зүгээр л мөрөөрөө нас барсан хэрэг. Эцэг нь биеэ хамгаалж чадаагүй гэж Иосифийг тэдний сургуулийн банди нар тэгэхэд дооглодог байжээ. Мань хүн тийм юм болоогүй, энэ бүхэн шал худлаа гэж сайн мэдэх тул тэдэнд тоож хариу хэлэлгүй, тамшаан мушилзаад зайлдаг байсан. Тэрээр хамт сурдаг тэр хүүхдүүдээ бүгдийг нь үзэн ядна. Мөн эдээрээ гайхуулдаг баячуул, ядуугаас ичдэг ядуучуудыг бас үзэж эс чадна.

Эцгийг нь Телавид тэнд нь оршуулсан гэх боловч чухам хаана оршуулсныг хэн ч мэдэхгүй. Мань хүн хүү нь атал бас мэдэхгүй. Гэтэл мань эр эцэгтээ хайртай байсан, эцэг нь ч өөрт нь хайртай, залхааж шийтгэдэггүй, хэзээ ч загнаж зүхдэггүй байсан. Харин толгойг нь энхрийлэн илж, дуу дуулна. ТЭРЭЭР хөгжмийн увдисыг эцгээсээ л өвлөж авчээ. Шашны сургуулийн найрал дуучдын нуруугаар хамгийн бага нь зогсдог арын эгнээнд мань эр зогсдог байсан. ТҮҮНИЙ хоолойг хамгийн сайн хоолой гэж үздэг, удирдагч багш нь түүнийг бас сонсгол сайтай гэж ярьдаг байсан. Энэ бүхэн эцгээсээ өвлөсөн зүйл, ер нь ч мань хүн эцэгтэйгээ төстэй, цаадах нь бас улаан шаргалдуу үстэй биеэр бага шиг хүн байсан, харин ээж нь бол нуруу өндөр, үс хар билээ. Эцэг нь тоглоом тохуунд дуртай, тоглоомын учрыг мэддэг хүн, эх нь бол тоглоомын учрыг ойлгодоггүй, бүрхэг дүнсгэр хүүхэн.

Нутгийнхан нь Горийг Сталины өөрийнх нь нэрээр нэрлэе гээд байгаа. Тэр хэрэггүй! Харин өмнөд Осетийн нийслэл Цхинвали хотыг өөрийнх нь нэрээр нэрлэвэл нэрлэг, тэгэх юм бол эцэгт нь болон эцгийнх нь бух осетин удам судрынханд дурсгал болно. Тэрээр өөрийнхөө эцэг гуталчин Виссарион Жугашвилийн дурсгалыг хүндэтгэж байдгийг эх нь харахад гэмгүй. Мунхаг хүүхэн биш юм чинь ойлгоно. Мань хүн зөвлөлтийн ард түмний нүдэн дээр гарцаагүй үлгэр жишээ хүү байх ёстой, тэгж гэмээж нь түүний дур илүү хүнлэг, илүү төрөлх дотно байх болно. Гэхдээ хүүхэд ахуй цаг нь мань хүний хувьд бол юунаас ч илүү эцэгтэй нь холбоотой.

Тэрээр эцэгтэйгээ Атени явдаг байснаа дахиад л дурсан санана. Тэндхийн тариачид усан узэм ургуулж, усан үзмээ хөлөөрөө гишгэлэн шүүсэлж, “Атенури” хэмээх сайхан дарсаа нүсэр нүсэр яндан вааранд юүлж байдагсан.

Тэгээд эцэг нь орой үдшийн цагаар найз нөхөдтэйгөө Атенийн дарс ууж, дуу дуулцгаахад гүржийн олон хоолойн сайхан дуу сэтгэл зүрхийг гөхөлзүүлэн байдаг болой. Хар архи ногоортлоо ууж агсам согтуу тавилцан, зодоон нүдээн, хутга шөвгөндөө хүрдэг орос харчуул шиг архидахгүй, жинхэнэ гүрж ёсоор уусан дарсандаа улам хөгжин, ааш зан нь улам уяран, сайхан ч ууна, сайхан ч дуулна. Гэхдээ орос харчуул гэдэг бол тоо хэмжээгээрээ ч, нутаг дэвсгэрээрээ ч аугаа ихэд тооцогдох оросын ард түмэн, түүхийг бүтээе гэвэл гагцхүү энэ ард түмэнтэй л бүтээж болно. Орост нийлсний үрээр гүрж омогтон үндэстэн хэвээрээ үлдсэн учраас гүржийн социализм бол нийт оросын социализмын нэг хэсэг нь юм.

Гэхдээ оросууд гэдэг бол гүржүүд биш. Шашны сургуульд байхад мань хүнийг бэртэнгэ гартай гээд хэнч хөнддөггүй, үүгээр гүржийн мах цусны ариун шударга ёс илэрдэг байлаа. Гэтэл хожим Баку, Батуми, Сибирь гээд хаана ч явж байхад хүмүүс түүний энэ согогийг огтхон харгалзаж үзэхгүй, хайр найргүй ширүүн дориун харалцаж асан. Тэрээр тэр үед бусдаас давуулан хэрцгийлж ширүүлж байж тэр бүхнийг тэсэж өнгөрөөжээ. Ленин түүнийг хэрцгий харьцаатай гэж буруушаадаг байсан, гэтэл аппаратын хэрцгийгээр л ард түмний хэрцгий бүдүүлгийг хазаарлаж байхаас өөр удирдах арга байхгүй шүү дээ. Гагцхүү сэхээтнүүд л ард түмэнд хий боловсон зан гаргадаг, тэгээд хожим нь өөрснөө хог новш мэт хуу шүүрдүүлэн хөсөр хаягддаг. Орос орон дахь ардчилал гэдэг бол зөвхөн хэрцгий догшин хүчний гар хөлийг суллах эрх чөлөө гэсэн үг гэдгийг мань эр бүр залуу байхдаа ойлгосон билээ. Байгалиас заяасан бүдүүлэг занг гагцхүү хүчирхэг засгаар дарж болно. Тийм засгийг диктатур гэнэ. Меншевикүүд ард түмнийг мэддэггүй учраас үүнийг ойлгоогүй, большевикууд ард түмнийг мэддэг учраас үүнийг ойлгосон. Чухам энэ учраас оросын социал демократуудын олонхи нь большевикуудыг дагаж, орос бус социал-демократууд нь меншевикүүдийн талд орсон юм. Большевизм бол оросын үзэгдэл, меншевизм бол оросынх биш. Бүх томоохон гүржүүдийн дотроос гагцхүү МАНЬ ХҮН ганцаараа оросын ард түмнийг ойлгосон учраас большевикуудтай нийлсэн. Ной Жордания, Церетели, Чхеизе мэтийн бусад гүржүүд оросын ард түмнийг мэдэхгүй байсны улмаас меншевикуудтэй нийлцгээсэн. Харин үнэнийг хэлэхэд МАНЬ ХҮН тэр үед газрыг улсын өмч болгохын эсрэг байсан. Тухайн цаг үедээ Ленин тэр хоёрын хэнийх нь зөв байсныг бүү мэд. Өнгөрсөн үед хэний зөв, хэний буруу байсан тухайд түүх ямар ч эргэлзээгүй хариу өгдөггүй, ялагчийн л өв байдаг. Гэхдээ МАНЬ ХҮН Ленинийг эсэргүүцье гээгүй. Тэрээр улс төрийн зүтгэлтэн болъё гэвэл гагцхүү большевикуудтай, Оростой зам нийлэхээс өөр аргагүй байсан учраас тэгсэн хэрэг. Тэрээр үндэстний асуудлыг их нухсан учраас үндэстний дотроос, хүмүүстэй адилхан хамгийн хүчтэй нь ялдаг, ард түмнүүдийн дотор улс төрийн зүтгэлтнүүдийн нэгэн адил эргүүлэх ард түмэн, дагах ард түмэн гэж байна гэдгийг гарцаагүй мэдэх билээ. Ард түмний тоог зуу гэж ярих Зөвлөлт Холбоот Улсын хувьд тэргүүлэх ганцхан ард түмэн байж болно. Тэр нь улсын хүн амын тэн хагасаас илүүг эзэлж байгаа оросын ард түмэн. Оросын гүрний дээрэнгүй үзэл орон нутгийн үндсэрхэх үзлийг төрүүлдэг учраас түүний эсрэг хайр найргүй тэмцэл ЗАРЛАХ хэрэгтэй. Гэхдээ нэгтгэн нягтруулах гол хүч нь оросын ард түмэн гэдгийг хоромхон зуур ч мартаж болохгүй. Корсик арлын Наполеон Бонапарт францчуудын хувьд франц хүн болж байсан лугаа адил мань хүн оросын ард түмний хувьд орос л байх ёстой.

Сталин зөвлөлгөөний тухай сэтгэл хангалуун байв. ТЭРЭЭР энэ зөвлөлгөөн дээр Москвагийн шинэчлэн байгуулалтыг санаачлагч, зохион байгуулагч болж ярьсан төдийгүй нэр нь хүртэл орос хүн бүрд эрхэм нандин зүйл болсон энэ хотыг МАНЬ ХҮН л Орост нь үлдээж өглөө. ТЭРЭЭР Москваг орос хүн болгоны мэддэг, төсөөлж байдаг тэр байдлаар нь үлдээж өглөө. Москваг хайрлан хүндэтгэх жинхэнэ оросын өрлөг сэтгэлийг танхимд сууж байсан Оросын соёлыг санаж сарвайж яваа нөгөө өргөн магнайтай сэхээтнүүд биш, харин МАНЬ ХҮН, чухамхүү МАНЬ ХҮН, гагцхүү МАНЬ ХҮН л хангаж өглөө. Тийм учраас Москва бол одоо ТҮҮНИЙ хот, ирээдүйн Москва бол ТҮҮНИЙ хөшөө дурсгал. Киров гэдэг орос хүн Ленинградад тийчигнэж, Ленинградыг шинэчлэн байгуулах тухай шуугиулж байгаа, гэтэл тэнд шинэчлэн байгуулах юм юу байгаа юм бэ? Ленинград бол жигдэрчихсэн хот, яаж ч янзлахын аргагүй аварга цохио гэсэн үг, тэгэхлээр Киров яаж ч чадахгүй цохио.

Гэхдээ МАНЬ ХҮН өөрийнхөө онцгой байдлыг үзүүлж байхад орь ганцаардлын сэтгэл түүнийг хэзээний эзэмдэн авдаг билээ. Цаадуул нь босож алга ташицгааж байна, гэтэл тэд өөрт нь хайргүй, харин өөрөөс нь айж байгаа, тийм учраас босож алга ташицгааж байгаа юм. Хэрвээ мань хүн ялагдсан байх юм бол тэд ёстой үнэн голоосоо баяр хөөр болж, ёс төртэй дэвслэн гишгэчих улс. Тэд нар түүний давамгай бөгөөд онцгой, давтагдашгүй байдлыг хүлцэхгүй, хүсэх ч үгүй, хүлцэж ч чадахгүй юм. Мань хүн бол тэдний хувьд номоо дутуу үзсэн банди, богино ухаантай барлаг. Тэр ч байтугай “журмын нөхөд” нь хүртэл түүний эрх засгийг бэхжүүлэхээс эмээн болгоомжилж хамтын удирдлагын тухай, Төв Хорооны ролийн тухай элдэв яриа гаргаж, түүхэнд нэг хүний ролийг үгүйсгэдэг Покровскийн сургууль руу санаатай юмыг нөөцлөн хадгалж, ингэснээрээ юуны өмнө намын түүх, Оросын түүхэнд МАНЬ ХҮНИЙ ролийг басамжлан бууруулах гэж байна.

Тэд нарын энэ санаа бүтэхгүй. ТЭРЭЭР Оросын шинэ түүхийг бүтээгээд зогсохгүй түүхэн үйл явдлыг үнэлэх шинэ жишиг хэмжүүр боловсруулна, гагцхүү тэгж байж л эрин үеийн тухай өнөөгийн болон ирээдүйн үеийнхнийг зөв ойлголттой болгож чадна. МАНЬ ХҮНИЙ эрин үеийн тухай шүү.

Цезарь, Наполеон энэ тэр нэр алдарт дуртайдаа эзэн хаад болоогүй, түүхэн шаардлагын дагуу болсон юм. Гагцхүү Цезарь л ганцаарчилсан эрх засагтай тулдаа бүдүүлэг зэрлэгчүүдийн довтолгооныг няцааж чадсан, гагцхүү Наполеон л эзэн хаан тулдаа Европыг буулгаж авч чадсан. Дээд засаг хаант төр шиг сүртэй байх ёстой, ард түмэн гагцхүү тийм засагт сөхрөн биширч, гагцхүү тийм засагт захирагдаж, гагцхүү тийм засгаас сүрдэн хүндэлнэ. Оросын түүхийн шинжлэх ухаан Догшин Иваныг харгис хар явдалтан мэтээр харуулдаг. Үнэн хэрэгтээ бол Догшин Иван улс төрийн аугаа их зүтгэлтэн байсан, Казань, Астрахань, Сибирийг Орост нийлүүлсэн, Оросын түүхэнд анх удаа, магадгүй зөвхөн Оросын түүхэнд ч биш байж болно, гадаад худалдааны онц эрхийг бий болгосон, Оросын хаадаас анх удаа бүх юм улсын эрх ашигт захирагдана хэмээн улсархах зарчмыг гол зарчим болгосон. Тайж ноёд төвлөрсөн хүчирхэг улс байгуулахыг эсэргүүцэж байсан, тийм учраас Догшин Иваны алдаа бол тэднийг цаазалж байсан явдал биш, харин дутуу цаазалж, гол гол тайж ноёдыг удам угсааг нь тасартал хүйс тэмтрээгүй явдал юм. Энэ үүднээс авч үзвэл эртний хүмүүс дайснаа гурав, дөрөв дэх үе хүртэл нь хүйс тэмтэрч үүрд хуу цэвэрлэдэг байсан тул илүү алсын хараатай байжээ.

Түүхийн шинжлэх ухаан тусгай цэргийн салбарын үүргийг бас буруу үнэлсэн байдаг. “Тусгай цэрэг”, “Тусгай цэргийн салбар” гэсэн ойлголтуудыг салгаж үзэх хэрэгтэй. Тусгай цэргийн салбар бол Догшин Иваны торгон цэрэг бөгөөд ноёд баядтай тэмцэх зориулгатай дэвшилт цэрэг юм. Тусгай цэрэг гэдэг бол гүйцэтгэгч учраас тэдний дунд алуурчид ч бас байх ёстой. Алах ялын тухай хуулийг өрлөг сэтгэлт төрийн түшмэд, гэгээн боловсролт хууль тогтоогчид баталж, харин алах ялыг алуурчид гүйцэтгэнэ.

Нэгдүгээр Пётр аугаа их захирагч байсан, шинэ Оросыг байгуулсан хүн. Гэтэл Покровский Пётрын тухай юу гэж бичлээ? Тэр мөрүүд нь энэ байна: “Зулгуй түүхчдийн аугаа их гэж нэрийдсэн Пётр бол цагтаа Эстонд нэг санваартны зарц хүүхэн явсан Екатеринатай суух гэж эхнэрээ сүмд хийж түгжсэн юм. Төрсөн хүүдээ өөрийн биеэр эрүү шүүлт тулгаж байгаад, дараа нь Петропавловын цайзын гянданд түүнийг нууцаар хороохыг тушаажээ... Тэрээр хоёр

дахь эхнэртээ яр тэмбүүгээ халдааж амжаад тэрхүү өвчнөөрөө нас баржээ...” Покровскийн Пётроос олж харсан юм ердөө л энэ!

“Түүхийн ухааны нэг чиглэлийн толгойлогч” ингэж донгоссон байгаа юм даа! Гэтэл Пётр Оросыг шал өөр болгосныг анзаарсангүй байх нь! Марксизмыг хий үгчлэн ойлгож түүхэнд нэг хүний ролийг үгүйсгэвэл чухам юунд хүргэж, ямар солиотой юм донгосож болдог нь энэ байна! Ийм байхад Ленин энэ нэгэн болхи нийгэм зүйчийг тэргүүн зэргийн түүхчдийн зиндаанд өргөн, түүний “Оросын түүхийн маш хураангуй найруулал” гэдэг Оросын бүх түүхт зүтгэлтнүүдийг авьяас билэггүй өчүүхэн амьтад болгон харуулсан хариугүй номыг магтсан байгаа юм. Ленин үүнийг яаж магтаж чадаа вэ? Ленин маань түүхэнд нэг хүний ролийг сайн ойлгож байсан хүн шүү дээ!

Покровский өөрийгөө ленинизмыг хадгалагч, Лениний үзэл бодлыг тайлбарлагч цорын ганц хүн болгохыг зорьжээ. Үгүй, өршөөгөөрэй! Владимир Ильич Лениний үзэл бодлыг тайлбарлагч цорын ганц хүн бол гагцхүү түүний залгамжлагч л байж чадна, гагцхүү түүний үйл хэргийг үргэлжлүүлэгч, гагцхүү түүний дараа улс орныг хөтөлж яваа хүн л байж чадна. Түүний залгамжлагч, үйл хэргийг нь үргэлжлүүлэгч бол Сталин, улс орныг Сталин жолоодож байна. Тэгэхлээр Лениний өвийг, түүний дотор түүхийн салбарын өвийг тайлбарлагч цорын ганц хүн Сталин болж таарч байна. ТЭРЭЭР энэ түүхийг өөрөө БҮТЭЭЖ байгаа юм чинь бүр ч аргагүй. Гэтэл нөхөр Покровский нийгмийн шинжлэх ухаануудыг боловсруулахад нөхөр Сталин яаманд хандив оруулсан тухай арван жилийн хугацаанд нэг ч үг дуугарсангүй. Төр улсыг удирдана гэдэг бол төрийн тухай онолыг боловсруулж байгаа хэрэг гэдгийг нөхөр Покровский ойлгохгүй байна гэж үү дээ? Ойлголгүй яахав. Харин нөхөр Сталиныг эрдэмтэн онолч ч биш гэж үзэх санаатай байгаа юм.

Покровскийн марксизмын эсрэг “түүхийн” чиглэлийг бут ниргэвэл таарна. Лениний нэр хүндийг өнөөдөр юу хэрэгтэй байна, маргааш юу хэрэгтэй болох вэ гэдэгт л зохицуулж ашиглах ёстой. Тэгэхлээр Лениний нэр хүндийг түүний залгамжлагч нь өвлөн авах ёстой. Сталин бол өнөөдрийн Ленин. Сталиныг үхэхийн цагт түүний залгамжлагч нь тэр үедээ өнөөдрийн Сталин гэгдэх болно. Гагцхүү ийм замаар л засаг төрийн дархан залгамжлах, эрин зуунд тэр нь хөдөлбөргүй тогтвортой байх явдлыг ханган бүрдүүлж болно. Шинжлэх ухаан бол Лениний жинхэнэ залгамжлагч нь Сталин, өөр залгамжлагч байх ямар ч үнэн байхгүй, Лениний өвийг өвлөх гэсэн өрсөлдөгчид бол нэр зээлдсэн арчаагүй амьтад, улс төрийн хутган үймүүлэгч, балмад этгээдүүд мөн гэдгийг л нотлох ёстой Сталин хэзээ ямагт Лениний дэргэд байсан гэдгийг түүхийн шинжлэх ухаан нотлох ёстой. Ленинийг цагаачилж явахад нь зөвхөн нарийн бичгийн дарга нь агсан Зиновьев, мөн тэнд туслах нь байсан Каменев биш, Орост практик ажил дээр намыг байгуулж байсан чухамхүү МАНЬ ХҮН л Ленинтэй байнга хамт байсан. Ийм ч учраас намыг Ленин Сталины нам гэж нэрлэж байгаа юм. Сталины Ленинтэй зөрж байсан аар саар бүх юм мартагдах ёстой, тэр бүхнийг түүхээс үүрд хасаж байх ёстой. Сталиныг өнөөдрийн Ленин болгож байгаа юм л түүхэнд үлдэх ёстой. Гол зорилго бол хүчирхэг социалист улсыг байгуулах явдал. Үүний тулд хүчирхэг засаг хэрэгтэй. Сталин бол энэ засгийн удирдагч, тэгэхлээр Ленинтэй хамт энэ засгийн тулгын чулууг тулалцаж, Ленинтэй хамт Октябрийн хувьсгалыг удирдсан хэрэг. Жон Рид Октябрийн эргэлтийн түүхийг өөр байдлаар тайлбарласан. Тийм Жон Рид бидэнд хэрэггүй.

Ингэвэл Түүхийг гуйвуулсан хэрэг болох уу? Үгүй, болохгүй. Октябрийн эргэлтийг Парис, Цюрих, Лондон л сууж байсан цагаачид хийгээгүй, нам хийсэн. Тэр цагаачид бол тэндээ маргаж шүүлцэж дадсан. Газрын сэрүүн асарт цуглаан хийж дэмий ярьж байсан улс, харин Орост байсан хувьсгалчид бол дуугарч чадахгүй буюу хагас дутуу дуугарахаас өөр аргагүй байсан юм. Гэтэл тэд нар, чухамхүү энэ эгэл даруухан намын ажилтнууд чинь л шийдвэрлэх мөчид олон түүнийг тэмцэлд босгож, хувьсгал хийлгэж, хожим мөн хувьсгалыг хамгаалахад тэднийг босгосон юм. Мань хүн намын эдгээр боловсон хүчний төлөөлөгч яг мөн бөгөөд тийм учраас Октябрийн түүхэнд ТЭДНИЙ гүйцэтгэсэн үүрэг бол МАНЬ ХҮНИЙ гүйцэтгэсэн үүрэг даруй мөн билээ. Түүхэнд нэг хүний гүйцэтгэх үүрэг, олон түмний гүйцэтгэх жинхэнэ үүрэг чинь чухам үүнд л оршиж байна. Иргэний дайнд мэргэжилтнүүд ажилд саад болохоос өөр нэмэр болоогүй, дайныг тэд ялуулаагүй, харин арми, хороо, отряд зохион байгуулсан түм түмэн коммунист, намын ажилтан нар л иргэний дайныг ялалтад хүргэсэн юм. МАНЬ ХҮН намын эдгээр боловсон хүчний төлөөлөгч, тэгэхлээр иргэний дайнд ТЭДНИЙ гүйцэтгэсэн үүрэг бол МАНЬ ХҮНИЙ гүйцэтгэсэн үүрэг, МАНЬ ХҮНИЙ гүйцэтгэсэн үүрэг бол намын гүйцэтгэсэн үүрэг даруй мөн болой.

Түүх, түүний дотор давын өмнө намын түүхийг яг ингэж, ийм зарчмаар бүтээх ёстой. Тэр хамтын удирдлага гэгч бол домог. Хүн төрөлхтний түүхэнд “хамтын удирдлага” гэж ямар ч юм байгаагүй. Ромын сенат уу? Тэр чинь юугаар төгслөө дөө? Цезариар төгссөн. Франтриумвират яалаа? Наполеоноор төгссөн. Хүн төрөлхтний түүх бол ангийн тэмцлийн түүх гэдэг ч үнэн дээ. Гэхдээ ангийн эрх ашгийг илэрхийлэгч нь жолоодогч байдаг учраас хүн төрөлхтний түүх түүний жолоодогч, захирагч нарын түүх юм. Ингэж идеализмын үнэр гарахгүй. Эрин үеийн сүр сүлд тэр эрин үеийг хэн бүтээж байна гэдгээр тодорхойлогдоно. Пётрын эрин үе Оросын түүхийн хамгийн сод үеийн нэг бөгөөд тэр үе бол Пётр сод хүн байсныг харуулж байна. Гуравдугаар Александрын төр барьсан хугацаа бол хамгийн үхээнц үе, энэ нь тэр өчүүхэн амьтны арчаагүй байдалтай дүйж байна.

Өглөө нь Борис тэрэгчинтэй ярьж тохиролцохоор яваад өгөв. Саша захиа бичихээр хоцорчээ.

...”Хайрт ээж минь!”

Түүнийг байцаадаг байсан нөгөө өрөөнд аваачиж ялыг нь сонсгосон ажээ. Нэг албан тушаалтан Онцгой зөвлөлгөөний тогтоол уншсан. Тавин наймдугаар зүйлийн арвын дагуу захиргааны журмаар урьдчилсан хорионд байсан хугацааг оруулан гурван жилээр Зүүн Сибирьт цөлөх ял оноосон байжээ.

–Гарын үсгээ зураарай!

Саша тэр цаасыг уншиж үзэв. Яасан гэж гурван жил оноосон нь тэнд бичээтэй байгаа юм болов уу? Бичсэн юм юу ч байсангүй. Энэ бол ерөөсөө ялын тогтоол ч биш, зүгээр нэг жагсаалтын нэг зүйл гэлтэй. Мань хүн тэр жагсаалтын тавд ч юм уу, хорин тавд ч юм уу, эсвэл магадгүй гурван зуун хорин тавд байгаа байх.

Саша гарын үсгээ тавив. Ялыг өглөө нь сонсгоод, өдөр нь ээжтэй нь уулзуулж, тэр оройноо замд нь гаргажээ.

Урьд орой нь хянагч ирж харандаа цаас өгөөд,

–Дуудуулж уулзах хүн хэн байна? гэжээ.

Тэрээр ээж, эцэг хоёрынхоо нэрийг бичив... Варяг яах вэ? Варя Иванова сүйт бүсгүй гээд биччихвэл болох байсан. Сүйт бүсгүйг нь тэд дуудаж өгөх албатай. Яахаараа заавал Варя байх билээ? Тэрээр тэр бүсгүйд хайртай сан билүү, эсвэл бүсгүй өөрт нь хайртай билүү? Ямар ч атугай л түүнийг хармаар санагджээ. “Ээрэм талын цэцэгхэн чиний минь, инээх дуу бишгүүрээс яруухан”. Тэр нэгэн уяхан дуу хоолой түүнд үгүйлэгдэж байсан аж. Гэвч Саша Варяг бичсэнгүй. Тэр бүсгүй ингэж уулзъя гэх үү, үгүй юу, өөрийг нь хүлээж байгаа юу, үгүй юу, өөрөө түүнд хэрэгтэй юу, үгүй юу? гэж бодсон хэрэг.

Хянагч Сашаг нэг умгар өрөөнд авчирч түгжчихээд явчихлаа. Мань хүн ширээний ард суух зуур сахлаа ургуулчихсан байхыг нь үзээд ээж нь яаж халаглах бол, шоронгийн хонгилоор явахад ээжид нь яасан аймаар байх бол хэмээн бодол болов.

Түлхүүр торхийн хянагчийн царай зэрвэсхэн харагдаж, цаана нь ээжийнх нь царай, ээжийнх нь буурал толгой зурсхийлээ. Хянагч ээжийг нь түүнд ойртуулахгүй гэж Сашаг нуруугаараа халхлан жишүү зогсоод ширээний нөгөө талд байгаа сандлыг ээжид нь зааж дохив. Жижигхэн буурал ээж нь Сашаг харалгүй толгой гудайсаар заасан зүг рүү бушуухан зүтгэлээ. Тэгээд суусан хойноо сая хараа өргөж хүүгээ үзээд тэр чигээрээ ширтчихэв. Уруул нь өмгөнөн, толгой нь үл мэдэг салганан байна.

Саша ээжийгээ харж инээмсэглэн байвч зүрх нь шимшрэн элэг эмтрэх шиг болов. Ээж нь өтөлсөн, шаналж гуньсан гэдэг нь жигтэйхэн, хоёр нүдээр нь дүүрэн зовлон хуржээ. Ээж нь

“миний габардин” гэдэг нөгөө хавар намрын элэгдэж хуучирсан пальтотойгоо ирснийг үзээд Саша аль хэдийн хавар болсныг саналаа. Тэрээр ээжийгээ нэгдүгээр сард л харсан билээ.

Цонхны доод хэсгийг цагаан будгаар будсан байх бөгөөд дээд хэсгээс нь гийх хаврын нарны туяа нөгөө хянагчийн ажиггүй сууж байгаа буланд тусжээ.

–Сахлаа хусах гэсэн чинь амжсангүй, өнөөдөр үсчин байсангүй гэж Саша хөгжүүн өгүүлэв.

Ээж нь уйлчихгүйг хичээн биеэ барьснаас болоод уруул нь өмгөнөж, толгой нь бөнжигнөсөн чигээрээ хүүгээ чимээгүй харсаар байв.

–Үсчин гэж энэ дотроосоо гарсан хүн болохоор ёстой зулгааж өгнө. Түүнээр сахлаа хусуулья гэх хүн ерөөсөө байхгүй, надад сахал зохиж байгаа юм биш биз, ингээд орхичихдог юм билүү?

Ээж нь дуугүй хэвээрээ толгой үл мэдэг дохин хүүгээ ширтэнэ.

–Нөгөөдүүл маань яаж байна? Эрүүл саруул биз дээ?

Тэрээр найз нарыгаа зүгээр байгаа биз гэж асуусан нь тэр байж.

Ээж нь ч тэр асуултыг нь ойлгожээ.

–Бүгдээрээ сайн, бүгд эрүүл саруул байгаа.

Гэтэл бүгдээрээ сайн сайхан байхад яагаад ч тэр юм бэ, гагцхүү ганц Сашагийн явдал ийм муу байх юм гэж бодохоос тэсэхүйеэ бэрх байв. Тэгээд тонгойж нүүрээ гараараа дараад уйлчихлаа.

–Боль боль, надад өөрт чинь хэлмээр юм байна.

Ээж нь алчуураа гаргаж нулимсаа арчив.

–Би давж заалдана, миний хэрэг бол шальтай юм биш, сургуультай холбоотой хэрэг.

Хянагч түүний үгийг тасдан,

–Хэргийн тухай ярихгүй шүү! гэв.

Ээж нь албаны бүдүүлэг харьцаагаар дээрэлхэхэд хуучин айдаг байсан бол энэ удаа ер айж мэгдсэнгүй. Царайд нь Сашагийн мэдэх нөгөө зөрүүд зан нь тодорч, тийнхүү биеэ барьж байгаад хүүгийнхээ үгийг дуустал сонслоо. Энэ бол Саша ээжээсээ олж үзсэн шинэ зүйл байжээ.

–Би Новосибирск рүү явах гэж байна, тэнд дажгүй дээ.

Тэрээр “Сибирь” гэж яримааргүй байсан тул “Новосибирск” гэж хэлсэн ажээ.

–Очих газраа хүрмэгц цахилгаан явуулна, дараа нь тэгээд захиа бичнэ. Би ажилд орно, тэгэхлээр надад мөнгө гуйвуулахын хэрэггүй.

–Би чамд зуун тавин рубль өгүүлж байгаа.

–Тийм ихээр яах юм бэ?

–Бас идэх юм, савхин гутал.

–Савхин гутал чинь сайн байна, харин идэх юм бол дэмий л дээ.

–Бас дулаан оймс, хүзүүний ороолт бий хэмээгээд ээж нь хараагаа дээшлүүлж, – Хэдэн жил өгсөн бэ? гэж асуув.

–Шалихгүй ээ, гурван жилийн чөлөөт цөллөг. Хагас жилийн дараа буцаад ирнэ. Аав ирж байна уу?

–Нэгдүгээр сард нэг ирсэн, харин сая бол би дуудлага явуулж чадсангүй, надад дөнгөж өчигдөр л утасдаж хэлсэн. Бие чинь ямар байна?

–Зүв зүгээр! Өвдөж барьсангүй, боломжийн хоолтой юм, ер нь амралтын газар гэсэн үг!

Тэрээр ээжийнхээ сэтгэлийг засах гэж хөгжилтэй байвч зовж байгааг нь ээж нь үзэж байгаа болохоор өөрөө бас зовж түүний тоглоом болгон ярьж байгаа юманд арга буюу инээмсэглэн, хүүгийнхээ сэтгэлийг сэргээх санаатай хүү нь ганцаараа хүн биш, түүний төлөө санаа тавих хүн бий гэдгийг мэдэж аваг хэмээн,

–Вера өөрийгөө дуудуулсангүй гэж тун их харамссан, уул нь надтай цуг ирсэн юм, даанч нааш нь оруулсангүй, бас Полинаг ч оруулсангүй гэв.

Саша нагац эгч нарынхаа тухай ер санаанд ороогүй байжээ.

Ээж нь урьдаас бэлтгэсэн үгээ одоо толгойд орж ирсэн зүйлтэй холилдуулан байж,

–Биеэ мэдэж яваарай, энэ бүх юм тэгээд өнгөрнө. Миний тухай санаа зовохын хэрэггүй, ээж нь ажилд орж байгаа гэв.

–Ямар ажилд?

–Угаалгын газар, хүлээн авагчаар орно. Зубовын цэцэрлэгт гудамжинд байдаг юм, санаа амар ойрхон, би бүр тохирчихсон.

–Балиар цагаан хэрэглэлтэй ноололдох гэж үү?!

–Би бүр тохирчихсон. Гэхдээ одоо биш л дээ, чам руу явж ирснийхээ дараа орно.

–Над руу явж яах юм бэ?

–Би чам дээр очно.

–За яахав, захидлаар харилцаж байгаад больё хэмээн Саша эвлэрэнгүй өгүүлээд, –Манай сургуулийнхнаас хүн үзэгдэнэ уу? гэж асуув.

–Нөгөө жижигхэн, солир...

Руночкин! Тэгэхлээр нөгөө хэд маань юманд өртөөгүй байх нь.

–Юу гэж ярьж байна?

–Орлогч захирлын тухай...

Криворучко! Тэгэхлээр мань хүн энд байх нь. Дьяков хуурсангүй.

–Хамаг хэрэг түүнд чинь л байгаа юм гэж Саша өгүүлэв.

Хянагч бослоо.

–Уулзалт дууссан.

–Хамаг хэргийн учир түүнд л дээ хэмээн Саша давтан хэлээд, –Маркт дамжуулаарай гэв.

Ээж нь орлогч захирлаас болж Саша баригдсан, энэ тухай Маркт уламжлах хэрэгтэй юм байна гэдгийг ойлгосноо мэдэгдэж толгой дохив. Тэрээр уламжлаад ямар ч ашиггүй гэж мэдэж байвч уламжлах л болно. Ямар ч юм ашиггүй. Үүнээс дордохгүй бол ингээд л дуусаг. Гурван жил гэдэг чинь нэг мэдэхэд л өнгөрнө, гурван жил чинь хэзээ нэгэн цагт дуусна шүү дээ.

–Би ямар ч мэдүүлэг өгөөгүй. Тэгж бас хэлээрэй. Хянагч хаалга онгойлгов.

–Иргэн гуай, гараарай!

Саша босож ээжийгээ тэврэхэд ээж нь мөрөнд нь толгойгоо шигтгэн наалаа.

–Яах чинь энэ вэ хэмээн Саша ээжийнхээ зөөлхөн буурал үсийг илбээд, –Ер юу ч болоогүй байхад та уйлж байх юм гэв.

–Иргэн гуай, гараарай!

Тэврэлдэж болохгүй, бие биедээ ч ойртож болохгүй, гэтэл цөмөөрөө л ингэж ойртож, цөмөөрөө л тэврэлдэж үнсэлдэнэ.

–За аль вэ, аль вэ хэмээн хянагч ээжийг нь мөрөөрөө сурамгай нудран үүд рүү зүглүүлж, –Гараарай гэж хэлээд байна шүү дээ! гэжээ.

Саша бүх юм сайн сайхан байна, өөрөө эрүүл саруул хөгжилтэй явна, юу ч ирүүлэхийн

хэрэггүй гэж ээждээ бичив. Өөрт нь Канскийн тойргийн Богучаны гацаа, өөрөө хүлээн авах гэж бичихийг мөн мэдэгдэв.

Борис их шазруун буцаж ирэв. Зам муу гэж айгаад явах хүн ерөөсөө олдохгүй, жигтэйхэн их мөнгө нэхэж байна гэнэ. Гэтэл комендантын газар хүлээх биш дээ, яаж л аргалдаг санж вэ, очсон л байх ёстой. Улаачийн хөлс гэж замын хагасын өртгөнд ч хүрэхгүй хэдхэн юм өгнө. Дахиад л “Ангийн үс бэлтгэх газраа” хоолонд оров. Нөгөө Игорь нэг буланд нь хоосон ширээний ард бэгцийгээд сууж байх ажээ.

–Гүнтэн харуулаа харсаар л байна, Дульсинея бид хоёрыг хүлээж байгаа нь тэр. Дульсинеяд шүлэг уншиж өгөх гэж, надаас үнэгүй хоол авах гэж хүлээж байгаа. Харин надаас горьдсоны гарз, би одоо өөрөө ажилгүйчүүдийн эгнээнд орсон гэж Борис өгүүлэв.

Тогооч авгай энэ удаа Соловейчикийг тосож гарч ирэлгүй, сав суулгаа хангинуулан байв.

–Борис Савельевич минь, үүнийг бүр амтшаачихжээ, өглөөнөөс хойш суугаад салдаггүй, ажилтан нараас санаа зовох юм, энэ чинь ямар юм түүдэг өглөгийн газар биш дээ.

–Би цаадахтай чинь ярилцана аа.

Борис хэдийн даргын албанаас гарсан ч гэсэн тогооч авгай өчигдрийнх шигээ түүний тавагтай шөл рүү нэг халбага цөцгий илүү хийлээ.

–Энэ авгайн байдлыг ойлгох хэрэгтэй, гуйлгачингуудыг гуанзанд оруулах ёсгүй, тэр хариуцлагыг өөрөө хүлээдэг юм гэж Борис хэлэв.

–Цаадах чинь өлөн байна гэж Саша хариулав.

–Саша, та аан гэж бай, цөллөгийнхнийг энд хооллохыг би зохицуулсан юм хэмээн Борис бухимдаж, –Одоо бол би явах гэж байгаа учраас надад пад алга. Гэхдээ үлдэж байгаа хүмүүсийн хувьд энэ бол үхэх сэхэхийн асуудал. Гэтэл журам мөрдөхгүй бол тэднийг эндээс хөөчихнө шүү дээ. Эндхийн ажилтан нарыг хоол ундандаа орсноос хойш хоёр цагийн орчимд ирж бай, шуугиж болохгүй, амьтны нүдэнд өртөөд байхын хэрэггүй, нам гүм, номхон томоотой, нямбай хичээнгүй байцгаах хэрэгтэй гэж би урьдаас анхааруулсан юм. Тэгэхэд байдаггүй шүү! Энэ этгээд өглөө хүрч ирчихээд өдөржин энд бүртэгнэн илүү харж, бас шүлэг уншиж байна, гэтэл шүлэг чинь янз янз байдаг, бас шүлгийн хорхойтнууд чинь ч янз янз байдаг... Та намайг ойлгож байгаа биз дээ?... гэв.

–Парист кафед хүмүүс цуглаж хэл амаа билүүдэцгээдэг, Игорь тийм юманд дасаж л дээ.

–Би дулаахан жорлон, усанд орох онгоц, харилцах утас, ресторан энэ тэрд дассан хүн. Гэхдээ түүнээсээ төсөөрснийг харж байгаа биз дээ гэж Борис зэрөв.

–Түүнийг сүүлчийн удаа хооллочихъё, мөнгийг нь би гаргана, цаадхаа дуудчих гэж Саша санал болгов.

Борис дал мөрөө хавчсанаа хөмсгөө зангидаад Игорийг хуруугаа дохин дуудав.

Игорь ингэж дохихыг хүлээж байсан учир тэр даруй цөгцгөнөж ширээнийхээ цаанаас эв хавгүй босоод царайчлангуй инээмсэглэсээр дөхөж ирэв.

–За яасан, зурсан зургийнхаа мөнгийг аваа юу? гэж Борис асуув.

–Хэд хоногийн дотор өгөхөөр амласан.

–Нөгөө хатагтай хаачаав?

–Валерия Андреевна Ленинград яваад өгсөн.

–Бүүр үү?

–Бүүр.

–“Бид хачин уулзацгаасан, мөн хачин салцгаана” хэмээн Борис амандаа бувгнаад –За, сууж үз гэв.

Игорь бушуухан сууж үнгэлдсэн саравчтай малгайгаа ширээн дээр тавьснаа тэр даруй санаа авч өвдөг рүүгээ шилжүүлэн тавилаа.

Борис Саша руу дохиж,

–Маргааш биднийг... гэтэл

Игорь өндөсхийж Саша руу мэхийв. Саша өөдөөс нь инээмсэглэлээ.

–За тэгэхлээр маргааш биднийг Ангара явуулна хэмээн Борис өгүүлээд, –Чамайг, бас бусад нөхдийг ийш нь урьдын адил оруулж байхаар би ярьж тохирсон. Гэхдээ энэ бол Монмартрад байдаг кафе биш гэдгийг чи ойлгох цаг болсон гэв.

–Ойлгож байна хэмээн Игорь ширээ рүү бөхөлзөн шивэгнэв.

–Энэ бол албан газрын хаалттай гуанз. Хоол идсэн бол яваад л өгөх хэрэгтэй. Мөнгө байхгүй бол үзэгдэхийн хэрэггүй. Энд тийм журамтай. Гэтэл чи тэр журмыг зөрчиж байна. Чамайг оруулахаа больчихож болно, энэ бол гайгүй хэрэг. Харин чамаас болоод бас бусдыг чинь, цөллөгийн чинь нөхдийг оруулахаа байчихна. Ойлгов уу?

–Ойлголоо, гэхдээ би цөллөгийн хүн биш гэж Игорь бачимдан хариулав.

–Чи чинь хэн бэ гуай вэ, хэлж өгөхгүй сэн болов уу? гэж Борис доогтой асуув.

–Намайг шүүж ял оноогоогүй, зүгээр дуудаад л Канск руу явж тэнд аж төр гэж л хэлсэн.

–Бүртгэлд тэмдэглүүлдэг үү?

–Тэмдэглүүлдэг.

–Паспорт бий юу?

–Надад зөвлөлтийн паспорт хэзээ ч байгаагүй.

–Чи яваад өгөх эрхтэй юу?

–Байхгүй.

–Тэгвэл чи яг л бид нарын өрөөсөн. За одоо явъя!

Борис, Игорь хоёр цонх руу очоод, Игорь таваг хүрэн манжингийн шөлтэй, Борис талх, халбагатай буцаж ирэв.

–Ид! хэмээн Борис тушааж, –Битгий яар, наадхыг чинь булаагаад авчих хүн байхгүй гэв.

Игорь таваг руугаа тонгойгоод чимээгүй идэж сууна.

–Чи чинь зураач шүү дээ, хөрөг зурж болно.

Игорь халбагаа тавьж хуруугаараа уруулаа арчаад,

–Зуруулах хүн алга, гэрэл зураг илүү төстэй бас тэгээд хямд байна гэнэ.

–Байгалийн зураг оролдсон ч болно, эндхийнхэн тийм зурагт дуртай, баяр дөхсөн үед клубт борлуулж мөнгө олж болно. Өөрийгөө язгууртан гэж бодоод байлгүй тархиа л ажиллуулах хэрэгтэй гэж Борис түүнийг шахав.

–Би өөрийгөө тэгж боддоггүй гэж Игорь шивэгнэв.

–Худлаа ярь, чи тэгж бодож байгаа. Намайг бол харц гэж үзэж байгаа.

Игорь толгой сэгсрэв.

–Үгүй, харц гэж үздэггүй.

–Хэн гэж үзэж байна?

Игорь толгойгоо гудайж халбагаа хөндий бариад,

–Би таныг бэртэгчин гэж үздэг гэв. Тэгээд таваг руугаа бүр тонгойлоо. Саша тэсэж чадалгүй жумалзав. Борисын царай цайчихав.

–Энэ чинь надад шинэ зүйл биш. Ичих нүүргүй танхай этгээд, бор болхи хүмүүс, харгис бэртэгчин энэ тэр чинь нэг үг. Лав л Орост нэг үг. Парист ямар байдгийг мэдэхгүй юм. Харин бор болхичуул нь, уучлаарай, өөрөөр хэлбэл нөгөө бэртэгчид нь ноёд язгууртнаа тэжээх үүрэгтэй болохоор би чамд долоон рубль үлдээе хэмээн Борис халааснаасаа мөнгө гаргаж долоон рубль тоолж аваад, –Энэ бол арван удаагийн хоолных. Үүнийг би гал тогоонд

орхино, тэгэхгүй бол чи ганцхан өдөр гударчихна. За тэгээд арван удаа хооллосныхоо дараа нэг бол шинэ бэртэгчин олно биз, тэр ч бүтэхгүй л дээ, эсвэл өөрөө ажил хийнэ биз, тэр ч бас эргэлзээтэй зүйл, эсвэл өлбөрч үхнэ биз, тэр нь л ортой болох байх гэв.

Тэрээр хоолны цонх руу очиж тогоочтой ярилцаад мөнгөө түүнд өгөв. Цаадах нь тэр мөнгийг мөнгө хураадаг таваг руугаа дурамжхан царайтай шидлээ.

Саша бослоо. Игорь ч бас босов. Малгай нь ойчиход мань хүн түүнийг тонгойж өөд нь авлаа.

Саша түүн рүү гар сунгаж,

–Баяртай, та тэгж ингэж байгаад эцэст нь учраа олох байх гэж би найдаж байна гэв.

–Хичээж л үзье хэмээн Игорь гунигтай хариулав.

–Байх тий! хэмээн Борис тоомжиргүй толгой дохив.

Өглөө нь уранхай хүрэм, хөлс тос болсон сөхөвчит малгай, элэгдсэн сөөхий гуталтай тэрэгчин тэдний байгаа айл руу хүрч ирлээ. Армаг тармаг шар сахалтай, үрчгэр царайтай эр дэндүү хямддуулчихав уу? гэсэн янзтай түгшин санааширч харах ажээ.

Саша, Борис хоёр юмаа тэргэн дээр тавихад айлын эзэгтэй жижигхэн ууттай идэх юм өгөв. Тэгээд үүднийхээ довжоон дээр тэдний араас харж зөндөө удаан зогсов. Борис тэрэгний араас алхлах зуур,

–Сайн ч бай, муу ч бай, энэ хүүхэн надад их тус болсон шүү, хөөрхий гэж гунигтайхан өгүүлэв.

Комендантын газар эднийг цуг явах нөхөд нь хүлээж байв. Володя Квачазе гэж шинэхэн хар хөвөнтэй хүрэмтэй өндөр гоё гүрж байна. Тэрээр хориход таван жил ял эдэлж байгаад тэр хугацаагаа дуусахаас сарын өмнө сайхь хүрмийг нормонд авсан аж. Минскийн хэвлэх үйлдвэрт байсан ахимаг насны ажилчин Ивашкин, арав хоногийн өлсгөлөн зарлаж Верхнеуральскт улс төрийн тусгай хорионд байж байгаад Канскт хүргэгдэж ирсэн Москвагийн комсомолын ажилтан байсан хоёр бас байв.

Соловейчик цонх руу тогшиж тэрэг ирсэн тухай, мөн Соловейчик, Александр Павлович Панкратов гэдэг хоёр хүн бас ирсэн тухай мэдэгдэв.

–Хулээж байгаарай!

Цонх хаагдлаа.

Володя Квачазе ихэмсэг хямсгар, үг дуугүй бардам байна. Зовж сульдаад ямар ч сөхөөгүй байгаа Карцев бас ярианд оролцохгүй урт сандал дээр нүдээ анин сууж байна.

–Одоо хэр тийшээ явах зам гараагүй гээд тэрэгчин зуун рубль мулзалж байна, гэтэл бидний өртөөний зардал тавин рубль байгаа. Зөрүүгийн нь нэмж төлөх болж байна гэж Борис хэлэв.

–Тэгж ярихгүй, цаадуул чинь гүйцээж төлөг гэж Володя тас зөрөв.

–Өгөх ёстой хэмжээгээр нь л өгч байна л даа, зун бол ч мэдээж хүрэх л мөнгө гэж Борис тайлбарлав.

–Зун ч явсан болж л байна, надад яарах юм алга гэж Володя хариулснаа, –Ер нь надад мөнгө байхгүй юм чинь бид хоосон яриа ярьж байна гэв.

–Надад ч бас байхгүй гэж Карцев нүдээ аниатай чигээрээ аяархан хэлэв.

–Бас надад ч байхгүй гэж Ивашкин гэмшингүй дуугаар өгүүлэв.

Цонх нээгдлээ.

–Ивашкин!.. Гарын үсгээ зураарай!

Ивашкин самгардан ийш тийш харав.

Квачазе түүнийг зайлуулаад өөрөө цонх руу толгой гоо шургуулж,

–Та нар нэг хүнд арван рубль өгч байна, гэтэл энэ тэрэг зуун рублийн хөлстэй байна гэв.

–Өгөх ёстойг нь л өгч байна.

Борис цонх руу бөхийж,

–Тэр болгон хүнд мөнгө алга, яах болж байна вэ? гэв.

–Яахыгаа бодоцгоо л доо гэх хариу сонсдов.

–Та нар л бодох болно доо! Та нар! гэж Володя хашгираад цонх руу балбав.

–Яагаад танхайраад байна?

–Даргыгаа дууд!

Ивашкин түүний ханцуйнаас татаж,

–За багачуул минь, хэрүүл хараал хийх хэрэггүй юмсан гэв.

Володя түүн рүү муухай харлаа.

Ахлах дэслэгч цолтой тарган эр хүрч ирэв.

–Хэнд гомдол байна?

-- Би унааны хөлс төлж чадах ч үгүй, тийм алба ч байхгүй гэж Володя Квачазе мөрөн дээгүүрээ ширэв татаж хэлэв.

–Явган явцгаахгүй юу.

–Юмаа яах вэ? Та аваад явах уу?

-- Чи хэнтэй ярьж байна?

–Хэнтэй ярьж байгаа нь надад пад алга... Биднийг хэн авах юм бэ? гэж л асууж байна.

– Өртөөний хөлсний хэмжээг дотоод хэргийн ардын комиссар баталсан юм гэж сайхь дарга биеэ барьж өгүүлэв.

–Тийм хөлсөөрөө танай тэр ардын комиссар л явдаг юм байгаа биз.

–Чи чинь яаж байна, буцаж хорихдоо очих гээ юу?

Володя байшингийн хажууд явган суучихлаа.

–Явуул л даа!

–Явуулж чадна шүү!

–Тэгэх л үгүй юу!

–Хуягууд! гэж дарга хашгирав.

Хоёр хуяг гарч ирээд Квачазег босгож хоёр гарыг нь ард нь хүлэв.

–Та нар хүллээ гээд наадхад чинь мөнгө байхгүй шүү дээ гэж Саша өгүүлэв.

–Чи бас тийшээ очмоор байна уу? гэж дарга минчийн бархирав.

–Тэглээ гээд надад ч бас мөнгө бий болохгүй гэж Саша тайван хэллээ.

Дарга эргэж хараад,

– Тэргийг хашаанд оруул гэж тушаав. Квачазег дотогш нь авч орлоо.

Ивашкин хоолой засаж,

–Хүүхдүүд минь, балрах вий нэг! гэв.

Карцев нүдээ аньсан хэвээр.

Цонх нээгдэв.

–Соловейчик!

Борис ойртож очив.

–Энэ тэрэгчинд одоо өртөөнийхөө зардлыг өгцгөөчих, үлдсэнийг Богучаныд тэндхийн бүрэн эрхт төлөөлөгч гүйцээж төлнө. Түүнд энэ дугтуйг өгөөрэй, дотор нь та нарын холбогдолтой бүх баримт бичиг байгаа. Гарцгаагаарай!

Тэд гудамж руу гарцгаалаа. Газрын хашааны хаалгаар морин тэрэг гарч ирж, араас нь винтовгой, морьтой хоёр хуяг гарлаа. Тэргэн дээр хүлээстэй Володя Квачазе хорсол шингэсэн хар нүдээрээ заналтайяа хялайн харж хэвтэнэ.

Тэр хэсгийнхэн хөдөллөө.

Эрэгтэй хүүхдүүд нь туйпуун ханын дэргэд зогсоцгоож, багш нар нь урт сандал дээр, охидууд нь газар сууцгаав. Цөм гоё хувцастай, баяр хөөртэй, ёслол төгөлдөр байлаа. Есдүгээр ангиа төгсөж, сургуулиа төгсгөн, сургуулиасаа үүрд салж байгаа нь энэ. Ганцхан Варя л ирсэнгүй.

Ийм өдөр ирэхгүй байх гэж! Нина дургүй нь хүрэхдээ багтран байв. Амьдралынхаа есөн жилийг цуг өнгөрөөсөн нөхөд, нэг ангийнхантайгаа салах ёс хийхгүй, дурсгал болгож зургаа хүртэл авахуулахгүй байх гэж байдаг аа. Өөрийг нь, төрсөн эгчийгээ багш нарын хамт олны өмнө ямар байдалд оруулахыгаа бодохгүй байх гэж.

Хэд хоногийн өмнө багш нарын өрөөнд байхад тооны багш түүн дээр ирж Варяг “авьяаслаг авхай” гэж магтжээ. “Авхай” гэдэг үгийг сонсоход тун эвгүй, зарсхийгээд явчихсан. Дүүд нь үнэхээр илт хуучны маяг мэдэгдэх болж, гэзгээ гэхэд л голоор нь хагалан шууд арагш нь самнана, гэхдээ зүгээр ар шилдээ аваачаад боочихгүй, эртний хөрөг зурган дээрх хүүхнүүд шиг хоёр чих рүүгээ давуулан арагш нь самнана. Бас бүх юмыг хажуу талаас нь, хөндлөнгөөс харж байгаа юм шиг толгойгоо жишүүлдэг нэг маягтай болчихсон.

Нина “авхай” гэдэг үгийг нийгмийн харш үг, тийм учраас доромжилсон үг хэмээн тооны багштай ам муруйх барагтайхан юм ярих нь гэж зэхсэн боловч цаадах нь ер муу юм болсон царайгүй харж байхын хамт физикийн багш, химийн багш хоёр бас Варяг сайшаан ярихад тэрээр санал нийлэн толгой дохиж, тэр гурав Варяг уралдаант шалгалтаас айх ёсгүй гэцгээн түүнийг дээд сургуульд орно гэдэгт хэн нь ч эргэлзэхгүй байв.

Нина тэгэхэд Варя зурагт ч сайн, шугам зурагт бол бүр ч сайн, тэгээд олон авьяастай хүн, яг оносон мэргэжлээ сонгох хэцүү байдаг гэхчлэнгийн ерөнхий юм хэлсэн болоод өнгөрчээ... Дүү нь өөрийнх нь үгэнд ордоггүй, санаснаараа амьдарч, зоргоороо авирладаг тухай үнэнээ хэлэлтэй нь биш дээ.

Тамхи татна. “Герцеговина флор” гэдэг нарийхан хайрцагтай арваад ширхэг тийм үнэтэй тамхи хаанаас гарч ирснийг асуухад “Худалдаж авсан юм” гэж хэнэггүй хариулсан. Гэртээ яагаад оройтож ирж байна, хаана ингэтлээ саатаж байна гэж асуухад “Танилындаа” гэж бас товчхон хариулсан. Тамхины мөнгө хаанаас олдог, ямар танилындаа өглөө болтол суудгаа огт хэлэхгүй. Тэгээд гадаадын пянз хэн өгдгийг нэг удаа асуухад ичих ч үгүй нүдээ онийлгоод “Би чинь японы тагнуулын газарт ажилладаг шүү дээ. Чи мэдэхгүй гэж үү?” гэж хэдэрлэсэн.

Ингэж хэдэрлэсэн нь хэрүүл гуйж байгаа нь тэр. Нина бухимдсан ч биеэ барьж тоглоом болгож инээмсэглэжээ.

–Тагнуулын ажилд ч гэсэн дээд боловсролтой хүнийг илүү үнэлдэг байх гэж бодож байна. Варюша минь, бид нар ямар үед амьдарч байна вэ, чи эргэн тойрноо хараач. Хүн болгон авьяас чадвараа хөгжүүлэх бололцоотой байна, энэ гол зүйл биш гэж үү? Чамд он жилээ алдаж байх ямар хэрэг байна, хүн бүхэн л суралцаж байна шүү дээ...

–Надад сонирхол алга, чи ойлгож байна уу?

–Тэгвэл чамд юу сонин байна? Хашаа хорооны үүдээр хөшилдөж байх сонин байна уу? хэмээн Нина хашгичиж эхлэв.

Хашаа хорооны үүд гэдэг үг яагаад аманд ороод ирснийг мань хүн эс мэдэвч, одоо хэрэг явдлын учир тэр үүдээр холхилдохтой огт хамаагүй гэдгийг ойлгож байгаа учир тэгж үг алдсандаа өөрийгөө зүхэв.

Варя юу хүсэж байна? Шугам зурагчин болох гэж уу? Бичээч үү? Сибирь луу Саша руу явах уу? Юу ч гэж хэлж мэднэ.

Варя тэр удаа галт тэрэгний буудал дээр Сашаг хуягуудад туугдаад явж байхыг хараад ухаан самууран багтарч, ихэр татан уйлж, ямар ч үг сонсохыг хүсэхгүй байсан билээ. Тэр хоёрыг трамвайгаар буцаж явахад том хүний, зүгээр ч үгүй хөндлөнгийн хүний мигуйн дээл өмссөн охин алчуураар нүүрээ таглаад уйлж явааг хүмүүс сониучирхан ажиглаж байсан билээ.

Гэртээ ирээд Нина түүнийг Софья Александровна руу очихын хэрэггүй гэж ятгахад цаадах нь санаандгүй зөвшөөрч бие нь арзайгаад байсан тул орондоо ороод хэвтээд өгчээ. Нойроо аваад тайвшрахлаар бүх юм мартагдана гэж Нина дотроо бодсоор дүүгээ дулаахан хөнжлөөр хучжээ. Варя оройжин, шөнөжингөө нам унтахдаа Зоя ирж нөгөө золгүй дээлийг авсныг ч мэдсэнгүй, Нинагийн өглөө юм хумаа эмхэлж сургууль руугаа явсныг ч мэдсэнгүй. Нина санаа зовж байсан тул эртхэн ирсэн боловч Варя гэртээ байсангүй.

Варя тэр өдөр оройтож ирэв. Софья Александровнагийн дотроо очсон гэнэ. Тэгээд мөн өчигдрийнх шигээ дулаан хөнжилд орж хэвтэв. Маргааш нь дахиад Софья Александровнагийн дотроо өнжжээ.

Хэсэг хугацааны дараа Нина ч гэсэн Софья Александровнагийн дотроо очив. Саша цөлөгдчихөөд бусад нь эрх чөлөөтэй яваагийн буруутан Нина юм шиг авгай түүнийг урьдынх шигээ сүйд майд бололгүй тоомжир муу тайхан угтжээ. Ингэж угтсаныг тэгж л ойлгох хэрэгтэй байв. Варя буйдан дээр ном уншаад сууж байснаа түүнийг орж ирэхэд нүдний булангаар харснаас хэтэрсэнгүй. Яриа ер эвлэж өгдөггүй ээ. Софья Александровна асуусан юманд ганц нэгхэн үгээр хариулж, тэр хоёрын иймэрхүү ярианы завсар Варягийн хуудсаа эргүүлж байгаа нь сонсдоно. Мань хүн ч гэсэн Нина Сашагаас урвасан, түүний төлөө юу ч хийгээгүй гэж үзэж байгаа бололтой.

Бодвол бодож л байг. Нина урьд нь Софья Александровна руу нэг их орж очдог байсан биш, одоо дахиад очих ч үгүй. Варяд учирлаж ярих ч үгүй. Надад хийсэн гэм буруу байхгүй, өөрийгөө зөвтгөж тайлбарлаад байх ч хэрэггүй.

Гэвч айлаас хөөгдөж гарсан мэт сэтгэлд нэг л эвгүй булингар хоцров. Мань хүн тэднийд тэс хөндлөнгийн хүн шиг байхад Варя яг өөрийн хүн шиг байна. Түүний зөрүүдлээд байгаагийн учир энэ, хамаг юмны учиг энд л байна.

Софья Александровна түүнд юу гэж ухуулж байгаа бол? Саша өөр талд байгаа юм чинь ээж нь мөн л өөр талд байгаа шүү дээ. Санаанд багтах юм биш, гэхдээ ийм л байгаа юм. Саша сургуульд байхдаа ямар байсныг Нина санаж байгаа, гэхдээ сургуулийн насны уяхан хонгор нөхөрлөл бол улс төрийн итгэл хүлээлгэхэд учир дутагдалтай. Хүүхэд ахуй нас бол хүүхэд

ахуй нас, амьдрал бол амьдрал. Тэдний бүлгээс хэн үлдээ вэ? Саша цөлөгдсөн. Макс Алс Дорнодод байгаа. Авгай авч ам бүлтэй болох байх. Шарок прокурорын газар орсон. Энэ ч бас сэтгэлд багтамгүй зүйл. Шарок - хувь заяаг шийдэгч буюу Нинагийн хувьд хувьсгалын үйл хэрэгт гуйвшгүй үнэнч байхын бэлэгдэл болсон прокурор хэмээх нэр бүхий ажилтай, гэтэл Саша Панкратов хувьсгалын эсэргүү гэгдээд цөлөгдсөн байдаг.

Гэлээ ч гэсэн түүхийн гарцаагүй нарийн учир холбогдол гэж байна. Хэрвээ коммунистыг зөвхөн хувийнх нь чанараар нь үнэлэх юм бол нам маань гойд сайхан сэтгэлтэй сэхээтнүүдийн эмх замбараагүй бөөгнөрөл болж хувирна.

За ингээд хэн үлдэж байна вэ? Вадим Марасевич уу? Тэр ч Арбатад тааралдахдаа хуучин янзаар сайхан зантай л байдаг юм. Сонин сэтгүүлд юм бичээд л, яг л гэрийнхэн шигээ хөлтэй аж төрж яваа, уул нь тэднийхэн Зөвлөлт засгийг арван долоодох жил дээр нь хүлээн зөвшөөрсөн улс шүү дээ.

Өнгө алдсан оготор даашинзтай Варя цонхны тавиур дээр хөл нүцгэн зогсоод цонхоо угааж байв. Хиртэй ус гарыг нь дагаж бас цонхны шилээр урсан давхар жаазны хооронд тунана.

—Чи яагаад ирж зургаа авахуулсангүй вэ?

—Мартчихаж. Санаад харсан чинь оройтчихсон байна билээ.

—Бусад ажил явдлаа санаж байгаа чинь бас яамай даа.

Варя даавуугаа түмпэнтэй ус руу шидчихээд үсрэн буулаа.

—Зургаа авахуулаагүй гэх үү хэмээн Варя шүүгээний шургуулганууд таталж хэдэн зураг гаргаж ширээн дээр тавиад,

— Зургадугаар ангийнх энэ, долоогийнх энэ, наймынх энэ байна. Тэгж яривал есийнх бас энэ байна, бид намар авахуулсан юм. Энэ хагас жилд тэгтлээ нэг их өөрчлөгдөөгүй. Харахгүй юу гэв.

Нина зураг руу нь харалгүй,

—Би хоёр хоногийн дараа семинарт явна. Чи юу хийхийгээ шийд. Чамайг дээд сургуульд орох бэлтгэл хийнэ гэвэл л би чамд тусална. Эс тэгвээс чи өөрөө л өөрийнхөө төлөө санаа тавих хэрэгтэй болно шүү гэж хүйтэн царайтай өгүүлэв.

—Чи нэг их санаа зовоод байх хэрэггүй гэж би бодож байна, би ажилд орж байгаа гэж Варя хариулав.

Галт тэрэгний буудал дээр Сашаг үзсэнээс болж уймарсан Варягийн сэтгэл ердөө амардаггүй ээ. Тэрээр Саша сахал үсэндээ баригдаж, царай нь цонхийж өтөлснийг үзээд дотор палхийж бас хуяг нарт туугдаж явааг нь мэдээд зүрх нь зогсчих шиг болсон билээ. Гэтэл хүмүүс вагонд бушуухан орж, арай гайгүй суудал олж авахаас өөр ямар ч бодолгүй түүний дэргэдүүр тавцан дээгүүр яаж гүйлдэж байлаа даа. Улаа бутарсан хацартай баяр хөөр болсон залуухан дарга

нар хуягуудад туугдаж яваа эр хүнийг нүдний булангаар ч болохноо зэрвэсхэн харалгүй, бүх юм зөв зүйтэй, ёсоороо байгаа гэдэгт итгэл төгс байж Алс Дорнод руу явцгааж байсан энэ тэрд Варя балмагдан гайхсан юм.

Саша өөрөө чемоданаа чирээд, хичнээн хүлцэнгүй явж байсныг үзээд Варя бүр онцгой цочирдсон ажээ. Өөрийнхөө хөлөөр цөллөг рүү явж байх гэж!

Яагаад мань хүн ноцолдож эсэргүүцэхгүй байсан бэ, яагаад түүнийг хүлээтэй авч явсангүй бэ? Хэрвээ мань хүн зодолдон ноцолдож, зулран тэмцэлдэж, эсэргүүцэн хашгирч явсан бол, хэрвээ түүний гар хөлийг хүлчихээд авч явсан бол хоёрхон хуяг биш бүхэл бүтэн салаа хэрэгтэй байх байсан, тэгсэн бол ердийн нийтийн вагонд биш төмөр сараалжтай тусгай вагонд оруулах байсан, тэгсэн бол хүмүүс тавцан дээгүүр тэгж жишимгүй гүйлдэж байхгүй сэн. Тэгсэн бол бас энэ шинэхэн дүрэмт хувцастай Максимтан, Серафимтангууд ийм дуулгавартай, ийм додигор, ийм өрөөсгөл байхгүй байсан байж ч мэдэх юм.

Саша бусдын эрхэнд оржээ.

Варя түүнд Бутырын шоронд эргэлт хүргэж өгдөг байхдаа шоронгийн нэвтрэхийн аргагүй зузаан өндөр хэрмийг тэндхийн зэвсэгт хүмүүс Сашагаас айхдаа түүнд зориулж барьсан мэт санадагсан. Гэтэл тэд нар түүнээс айдаггүй, тэр тэдэнд аймшигтай бус, харин тэд нар түүнд аймшигтай байсан ажээ. Тийм ч учраас өрөөсөн гараараа аваад шидэлж орхимоор хоёр нялх шахуу хуягийн дунд тийм хүлцэнгүй явж байсан байх нь. Шидэлж чадсангүй.

Гэвч Варя Софья Александровнаг өрөвдөхдөө өдөр болгон тэднийд очиж, элдэв сонин дуулгаж, тайтгаруулж сатааруулахыг хичээнэ. Софья Александровнаг угаалгын газар ажилд орсны дараа түүний өмнөөс дэлгүүрээр явж тасалбарыг нь бараа болгож өгнө.

Софья Александровна Сашаг шударга, эрэлхэг зоригтой, аймшиггүй хэмээн магтана. Варя түүнтэй зөрдөггүй ч гэсэн дотроо Сашаг эрэлхэг зоригтой гэж үзэхээ больжээ. Өөрийгөө тэгж доромжлуулахаа тоохгүй байгааг бодоход яг бусдын адил амьтан гэсэн үг. Ер нь ч хэзээний л бусад шиг байж, хүний тушаал л биелүүлж явсан байх нь. Тэгээд одоо цөллөгт яв гэж тушаасан учир мань хүн цөллөгт явж байгаа нь тэр байж. Чемоданаа чирээд буудлын тавцан дээгүүр хүлцэнгүй явж байсан шүү.

Софья Александровна Сашагийн өрөөг хөлслүүлэхээр шийдсэн тул Варя тэр өрөөг шинэ эзэгтэйд нь зориулж цэвэрлэх ажилд туслалцав. Шүүгээн дотор тасарсан газар нь зангидаж бэхэлсэн урт оосортой хуучирч муудсан шаахайтай тэшүүр хэвтэж байлаа. Сашагийн тэшүүр! Софья Александровна тэр тэшүүрийг авснаа хүүгийнхээ бага байхыг санаад уйлчихав.

Варягийн хувьд энэ тэшүүр мөсөн гулгуурын жавартай цэнгэг агаар, дэнлүүний мөсөн дээр туссан бүдэгхэн дугуй туяа, хүнхэр саравчинд тоглож буй хөгжимчид, буфетны халуун цай, хувцас солих газрын хөл үймээнийг санагдуулав. Өөрийнх нь шаахайн тасархай оосор бас тийм болхи зангилаануудтай байж билээ. Тэгээд шаахайн нүхээр оосроо сүвлэхэд тэр зангилаанууд нь тээглэчихээд зөндөө удаан ноцолдох хэрэг гардаг сан.

Варя бас Саша тэр хоёр “Арбатын нүхэнд” яаж цуг байснаа, тэгэхэд түүнийг мөсөн гулгуур

дээр очихыг урьснаа дурсан санав. Тэгэхэд Саша бүгдийг дийлээд бүх юм амар жимэр дууссан шиг санагдаж байсан юм. Тэр хоёр хөөрөн хөгжилдөж, танго, румба бүжиглэж, хөгжимчид “Ноён Браун”, “Хар нүд”, “Ээ нимбэг минь, нимбэг минь”, “Цэцэглэх хаврын цагаар би хаа ч хэсэж явсан” энэ тэрийг тоглож байж билээ... Саша бас танихгүй бүсгүйг хамгаалж тун зоригтой байсан.

Тэгэхэд “Арбатын нүхэнд” байхад Саша баатар эр шиг санагдаж байжээ.

Одоо Варя түүний баатар биш гэдгийг ойлгожээ. Ер нь ч баатар гэж байхгүй юм байна.

Харин нар, агаар байхгүй, газар давхраас нь гашилсан байцаа, муудаж байгаа төмсний үнэр ханхалсан нүсэр том байшин байна. Хэрүүл маргаан, шүүх зарга тасрахгүй хүн нь олдсон нийтийн орон сууц байна. Муурын үнэр шингэчихсэн шатнууд байна. Талх, саахар, тосны оочер байна. Бараа нь олддоггүй тасалбар байна. Нөхөөстэй өмдтэй сэхээтэн эрчүүд байна. Үнгэлдэж нооройсон цамцтай сэхээтэн эмэгтэйчүүд байна.

Бас энүүхэн Арбат, Смоленскийн талбай хоёрын уулзвар дээр бүх юм байдаг торгоны дэлгүүр байна. Гэхдээ энэ бол алт, гадаадын валюттай хүнд л тэр. Бас л энүүхэнд, Плотниковын хөндлөн гудамд бүх юм байдаг хаалттай хуваарилах газар байна. Бас энэ л Арбатад “Арбатын нүх” гэж мөн л бүх юм байдаг газар байна. Гэвч их мөнгөтэй хүнд л тэр шүү дээ. Энэ бол шударга бус байдал!

Варя зургадугаар ангид байхдаа урьд нь жүжигчин байсан Елена Павловнагийн удирддаг жүжгийн дугуйланд явдаг байжээ. Идэвхтнүүд энэ багшийг Островский, Грибоедовын жүжгийг тавиад зөвлөлтийн зохиогчдын ухуулгын жүжгийг тавихгүй байна гэж буруутгасан юм. Елена Павловнаг ажлаас нь халчихсан, гэтэл тэрээр өвчтэй охиноо асарч тэтгэдэг байжээ. Настай хүнийг ингэж үмх талхнаас нь салгадаг хэрцгий явдлыг Варя ихэд гайхсан билээ. Түүнээс хойш гурван жил болоход тийм өчүүхэн хөлсөөр ажиллах багш олдоогүй учир жүжгийн дугуйланг сэргээж ажиллуулаагүй. Тэгээд нугаслачих нь тэр. Гэтэл үүний хариуцлагыг хэн ч хүлээгээгүй. Сургуулийн хурал цуглаан дээр бүх юмыг урьдаас шийдчихсэн байдаг тул худлаа гар өргөхийг өөрийгөө доромжилсон хэрэг хэмээн Варя хурлаас оргочихно. Гэтэл Нинка нь тэднийг зөвтгөн хамгаална, Нинка ч мунхаг толгой доо, ямар ч асуултад бэлэн хариулттай байхыг нь яах вэ. Асуулт нь янз бүр, гэтэл хариулт нь ав адилхан.

Варя яг өөр шиг нь байх суух газраа олж ядсан банди нар, охидтой хашаан дотор нийлж амиа аргална. Тамхи татаж болохгүй, гэвч банди нар нь татна, уруулаа будах гэмтэй, гэвч охидууд будаж, оо энгэсэг тавьж, үсээ урт ургуулж, сиймхий сэмжин оймс өмсөж, хурц өнгийн алчуур зангидацгаана.

Гэтэл энэ бүхэн ч одоо сонирхолгүй болжээ. Галт тэрэгний буудал дээр сэтгэл уймарснаас болж Варя өөр янзаар бие даах юм руу зүтгэлэх болов. Яг энэ үеэр Варя өөр бүлэгт татагдах болсныг ч хэлэх үү.

Варя нэг удаа Арбатад явж байгаад Вика Марасевич дөч эргэм насны нүдэнд хүйтэн хээнцэр хүнтэй цуг явж байхад нь тааралдав.

Вика урьд өмнө нь Варяг тоодоггүй байсан атал энэ удаа зогтуссан төдийгүй түүнийг тэвэрч сүйд болжээ.

–Виталий, миний найз Варя, сургуулийн маань үерхдэг охин...

Варя энэ яльгүй алдааг дотроо анаж авав. Тавхан ангийн л зөрөө л дөө...

–Манай Арбатад ямар хөөрхөн охид байдаг гээч хэмээн Вика яриагаа лавшруулж, –Тийм байна уу? Виталик, чи юу хэлэхсэн бол? гэв.

Виталик хэлэх үгээ олохгүй муухай хөмсгөө магнай дээрээ гаргаж гараа алдлав.

–Чи бүр алга болчих юм, утасдах ч үгүй, орж гарах ч үгүй.

Варя Викад хэзээ ч утасдаж байгаагүй, тэднийхээр хэзээ ч орж байгаагүй билээ.

–Нина ямар яваа вэ?

–Дажгүй, ажлаа хийж байгаа.

–Нина гэж энэний эгч хэмээн Вика цаадахдаа тайлбарлаад,

-- Утасдаарай, би ч чам руу утасдана аа гэв.

Вика цүнхнээсээ тэмдэглэлийнхээ дэвтрийг гаргаж хэдэн хуудас эргүүлж байгаад тэдний утасны дугаарыг хэлэв.

–Өөрчлөгдөөгүй биз?

–Үгүй ээ.

–За, битгий таг чиг болчихоорой.

Хоёр хоногийн дараа Вика утасдаж, гэртээ ир гэв. Варя очлоо.

Вика харваас тун сая боссон бололтой, гэрийн халаадтайгаа байх бөгөөд оймс, торгомсог дотуур хувцас, даашинз энэ тэр нь олбогт сандал дээр хөглөрөх ажээ. Түүний хувьд энэ муусайн хувцас юу ч биш, энэ мэтэд нүд тайлсан нь илт.

Вика өмсгөлөө харуулна гэж өдий төдий банзал, костюм, цув, зургаа долоон хос шаахай үзүүлэв. Гурвалсан толины өмнөх янз янзын шил савнуудын дунд байсан модон хайрцгийг жижигхэн түлхүүрээр онгойлгоход дотор нь баахан ээмэг, сондор, хатгадаг зүүлт энэ тэр байв. Харин ингэхдээ бардамнан сайрхсан бус, одоо юу моодонд байгаа, хилийн чанадад юу зүүж байгаа энэ тэрийг биечлэн үзүүлж, гадаадын сэтгүүлүүд харуулав. Тэдгээр сэтгүүлийн хуудаснаас үнэт үслэг хэвнэгтэй, биеийн өнгөт оймстой, лакадсан өндөр өсгийтэй бээрэг хээнцэр хүүхнүүд мишээх аж.

Дараа нь тэр хоёр ор луу тавьсан явган ширээний ард сууж кофе ууж “Бенедиктин” хэмээх дарснаас хуруувчин чинээ жүнзээр амталж, алтан тасамтай уртын урт янжуур татацгаалаа.

Үнэхээр шал өөр орчлон юм аа! Тэнд оочерт зогсож байж тасалбараар юухан авна. Энд бол кофе ууж, янжуур татаж, хилийн чанад дахь янз маягийг шохоорхон байна.

–Чиний над руу ирснийг Нина мэдэж байгаа юу?

–Үгүй.

–Надтай тааралдсанаа түүнд ярьсан уу?

–Би илтгэх үүрэгтэй юм уу?

–Тэр чинь зөв хэмээн Вика түүнийг магтаж,

–Би эгчийг чинь хүндэтгэдэг юм, бид хоёр есөн жил хамт сурсан. Гэхдээ цаадах чинь эр хүний сэтгэцтэй, эм хүний сонирхдог ямар ч юм түүнд огт пад байхгүй, намайг ад үздэг юм, би мэднэ. Би тэглээ гэж түүнийг буруушааж байгаа юм биш, түүний хүсэл тэмүүллийг хүндэлж байна. Тэр чинь олон нийтийн ажилд гарамгай, энэ бол сайн, маш сайн хэрэг! Гэвч хүн болгон тийм болж төрдөггүй байна гэв.

–Нина бусдыг яг л өөр шигээ байлгахыг хүсдэг юм гэж Варя өгүүлэв.

Вика эгшигт хайрцгаа чангалах зуур,

–Чи хэнийг сонсох дуртай вэ? Мелеховыг уу? “Охид минь, найздаа хэлээрэй...” За, тэрийг ч хичнээн сонсох вэ дээ?.. гэв.

Тэгээд Вертинскийг, дараа нь Лещенкогийн пянзыг тавив. “Балтийн хязгаараар хэрэн хэссээр бүхнийг би залхааж гүйцлээ...”

–Виталийд ёстой гайхамшигтай пянзууд бий. Хоёулаа тэгж байгаад очиж нэг сонсоно оо.

Варя инээд алдав.

–Тэднийд үү?

–Чамд дургүйцэх юм юу байна?

–Хүн сармагчингаас гаралтайг би даанч мэдэлгүй яах вэ, гэвч тэднийд очиж яахсан билээ?

–Чи түүнийг дутуу үнэлж байна. Виталик чинь тун их нөлөө бүхий иргэн шүү.

–Бусдад л нөлөөлж байг даа.

–Чи театрын сургуульд орох гээгүй биз?

–Би энэ жил ямар ч сургуульд орохгүй. Ажил хийнэ.

–Хаана?

–Аль нэг газар шугам зурагчнаар.

–Варя! хэмээн Вика дуу алдаж,

–Виталий чамайг нүд ирмэхийн зуур оруулаад өгнө. Мань хүний найз нь Москвагаар дүүрэн байгаа. Би одоо утасдаад орхиё гэв.

Тэгээд урт оосортой харилцуураа ор луугаа татаж авчраад ноймероо эргүүлэв.

–Вика байна.

Утаснаас жааз хөгжим сонсдоно.

–Цаад хууршуу юмаа дуугүй болго! гэж Вика тушаал буулгаад, –Варя, нөгөө Арбатын сургуулийн найз маань манайд байна... За, тэгье хэмээн Варя руу толгой дохин, –Чамд мэнд... гэхэд,

–Мерси! гэж Варя талархал илэрхийлэв.

–Хүүш, энэ маань шугам зурагчны ажилд орох санаатай гэнэ. Сургууль нь... шугам зураг зохион бүтээх чиглэлтэй байсан, ёстой сайхан зурна шүү. Юу гэнэ ээ? Танайд хэн байгаа юм бэ?.. Үгүй ээ, сонин биш... Чи түүнийг хаанаас олох юм бэ? (Викад хэлэхэд санаанд нь таараад тийшээ очиж болохоор хүний тухай ярилцаж байгаа бололтой.) Үгүй чишш! Нөгөөдөр, хагас сайнд гэж тохиръё. Эрик заавал ирнэ. “Метрополь” руу явцгаая... Одоо асуугаад орхиё... Варя, чи нөгөөдөр завтай юу?

–Завтай.

–Завтай гэнэ. Бас Эрик байна... Байна гэж би чамд хэлж байна! Тэгэхгүй бол Варя бид хоёр очихгүй. Тэр заавал байх ёстой, үүнийг бодоорой...

Вика харилцуураа тавив.

–Бидэнтэй бас нэг хүн байна, нэрийг нь Эрик гэдэг юм. Магнитын барилга байгууламжийн тоног төхөөрөмжөөр ажилладаг хүн.

Тэрээр Варя руу харлаа.

–Нөгөөдөр зургаан цагт манайд хүрээд ир, эндээс явцгаана. Чиний ажлын тухай хэлэлцэж шийдэцгээнэ. Аян хамтад нь жаахан зугаацацгаая.

Тэгээд инээмсэглэн мушилзаж Варягийн үсийг гараараа шөргөөлөв.

–Чамайг Павел Михайловичтай уулзуулж болно шүү, тэр хүн үсийг чинь сайхан янзлаад өгнө.

Павел Михайлович гэдэг нь цуутай үсчин, тэдний үсчингийн газар “Поль” нэртэй агаад “Прага” рестораны ойролцоо байдаг юм. Үсээ засуулдаг хүүхнүүд нь тухайн үедээ түүнийг тийнхүү “Ноён Поль” гэж нэрлэх болжээ. Вика түүнийг хоёр нэрээр нь гуайлж байгаа нь түүнтэй дотно танил гэдгээ цохсон хэрэг.

Маргааш яаж хувцаслаж юугаа өмсөж “Метрополь” явна даа? Варя өөрийгөө Викагийн дэргэд байгаагаар зүйрлэн бодоход нэг муу элэгдчихсэн цамцтай охин л байх царайтай. Байгаа бүх юм нь цөм янз маяг хуучирч өөдтэй нүдэнд тусах юмгүй болжээ. Гэтэл оймс яах вэ? Бас өндөр өсгийг яах вэ? Тэрээр шүүгээгээ онгичиж, тааралдсан юмаа нэг өмсөж, нэг тайлна. Ганцхан хуучин хөх даашинз л гайгүй зохиж байв. Зоягийн өндөр өсгийтийг дахин гуйх хэрэг гарах нь, одоо яая гэх вэ дээ.

Вика нэл өлбөн шигтгэсэн, урд хормой нь дөнгөж өвдөг давсан, ар хормой нь хөлийн булчин өнгөрсөн, хоёр ташаа нь бас яльгүй дээр доор даашинз өмссөн байв. Тэр нь цээж, бүсэлхийгээр нь сайхан бариу таарчээ. Толигор зөөлөн арьстай, том бор нүдтэй, цайвар хонгор үстэй, хараа булаам гунхалзсан өндөр хүүхэн.

Тэрээр даашинзаа тайлж цайны сарнай цэцгэн өнгөтэй дотуур хувцастайгаа нүцгэн сууж үсээ янз янзаар самнан, долоон цагт уулзахаар болзоод одоо цаг найм болох гэж байгаа атал огт яарахгүй байх ажээ.

Утас дуугарч Виталий тэр хоёр тун ярвигтай хэлэлцээ явуулж байгаа бололтой. Цаадах нь Эрикийг олохгүй, өөрийндөө хүрээд ир гэж санал тавьжээ. Вика, өөрсдийгөө эндээ сайхан байна гэж зөрөв.

–Чамтай байвал бүр ч сайхан байхсан, чи даанч утсаа сахиж байх ёстой нь тоогүй байна.

Вика гурвалсан толины өмнө дан дотуур хувцастайгаа суусаар билээ.

–Ленка Будягина танайхаар очдог уу?

–Шинэ жилээс хойш ирээгүй.

–Юрка руу очиж байгаа болов уу?

–Би үзээгүй, Юрка ховч тагнуул, би түүнийг ёстой үзэж чаддаггүй юм.

Тэдний гэрт иймэрхүү үг яриа ярьдаггүй учраас Вика эргэдэг сандалтайгаа хамт эргэн Варя руу хилэгнэн харав. Вика ч, ах нь ч, эцэг нь ч, ер нь эдний зиндааныхан цөмөөрөө байгаа бодит байдлыг заяасан зүйл, аж төрөхийн зайлшгүй байх нөхцөл хэмээн хүлээн авчээ. Ийнхүү хүлээн авсны илрэх хэлбэр эгэлхэн ажээ. Аливаад даруухан, хүндэтгэж хандахын хамт битүүгээр егөх, явуулах, явган шог буюу салаа утгатай юм ярих явдал ерөөс байж болохгүй гэж үзнэ. Ер нь элдэв яриа яаж төгсдөгийг хүн бүхэн мэднэ.

–Варя, чи нэг юм сайн тогтоож ав! Би чамайг олон хүнтэй танилцуулна. Тэд элдэв юманд хамаагүй байж болохгүй байр суурь эзэлдэг улс. Тэгэхлээр чи хэлэх үгээ цэгнэх ёстой болно шүү.

–Би юу хэлчихээ вэ?

Вика өөрөө тийм үг хэлээгүй болохоор “ховч тагнуул” гэдэг үгийг давгаж хэлэхийг хүссэнгүй.

–Чиний үг хэлнээс чинь гудамжны үнэр ханхалж байна.

Варя дүрсхийгээд явчихлаа.

–Би гудамжинд өссөн хүн.

–Чи намайг ойлгосонгүй. Би бүдүүлэг байдлын тухай яриагүй, миний толгойд тийм бодол огт байгаагүй. Гэхдээ зарим нэг юмнаас, зарим нэг үгнээс зайдуухан байсан нь дээр. Юра өөрийнхөө ажил явдлыг хийж байгаа, чи бид хоёр бол түүний учрыг мэдэхгүй шүү дээ.

Варя дуугарсангүй. Варя үнэхээр учрыг нь олно гэж үү?.. Шоронгийн оочерийн л учрыг олдог эс юм бол... Гэхдээ Викагийн зөв. Энд шинэ, үл таних орчин байна, тэгэхлээр өөр байдалтай байх хэрэгтэй.

–Би зүгээр л Шарокт дургүй юм, жигшмээр хачин хардаг хүн шүү.

Вика түүнийг тэвэрч авлаа.

–Чи ухаантай бүсгүй. “Амьдрал богинохон” гэдэг бол улиг болсон үг, гэхдээ үнэний хувьтай шүү. Бусад нь бол чи бид хоёрт хамаагүй. Тийм биз дээ?

Варяг Викагийн ирэхэд тэднийд чив чимээгүй байжээ. Есөн цагийн үед байшин амилах мэт хонгилд хөлийн чимээ гарч, хаалга дуугаран хүний дуу сонсдох болов. Эднийх хүн болгон өөрийнхөөрөө аж төрж, нэгнийх нь явдал нөгөөдөө падгүй байдаг учир Вика энэ дуу чимээг өчүүхэн төдий ч тоосонгүй. Вадим гэхэд л дүү рүүгээ ганц удаа ч болохноо шагайсангүй. Варя энэ байдлыг өөрийнхөө нийтийн байртай, Нинагийн залхаж цөхрөм хяналтын дор түүнтэй цуг аж төрдөг ганц өрөөтэйгөө зүйрлэж бодлоо.

Арван цагт Виталий утасдаж тэр хоёрыг арван таван минутын дараа, түүнээс хэтрэлгүйгээр доошоо орц руугаа буугаарай гэж хэлжээ.

Вика яаралгүй үсээ янзалж, уруулынхаа будгийг шинэтгээд, нөгөө өлбөн шигтгэсэн даашинзаа өмсөв.

Эрик гэдэг нь арагш гөлчийтөл самнасан гялгар хар үстэй өндөр гоолиг залуу ажээ. Өмссөн костюм, тэр костюм нь биед нь таарсан байдлаас үзэхэд гадаадын хүн гэдэг нь илт байв. Тэрээр машинаасаа гарч ирээд жууз тэргэндээ хөдөөгийн бүсгүйчүүдийг урьж оруулж байгаа хунтайзын донжтой машиныхаа хаалгыг Варя Вика хоёрт онгойлгож өгөв. Тэгээд жолооныхоо ард сууж замын туршид нэг ч үг дуугаралгүй явсаар “Метрополийн” дэргэд ирж бүсгүйчүүдийг дэмнэж машинаас гаргав.

Рестораны үүдэнд оочерлож байсан хүмүүс ярагдаж, хантаазтай өмсгөлтэй хаалгачин үүдээ нээж, хар костюмтай ахлах үйлчлэгч тосон ирж, хүн пиг дүүрсэн танхимд тэр даруй сул ширээ олдож, зөөгч хоол ундны хэрэгсэл тавьж эхэллээ. Хаалгачин, өлгүүрийн хүн, ахлах үйлчлэгч, зөөгч энэ тэртэй Виталий ярилцаж байвч цөмөөрөө Эрикийн төлөө санаа

тавьцгааж байгааг Варя ажиглав. Хамгаас илүү Виталий л мэрийж байна. Тэрээр энд гаршсан хүний хувьд хоолны цэстэй танилцаж юу захиалахыг бусдадаа зөвлөн, жижигхэн дэвтэр харандаа барьсан зөөгч хэлснийг нь тэмдэглэж авна.

Вика шал өөр болчихжээ. Рестораны оочер, хаалгачин, өлгүүрийн хүн, ахлах үйлчлэгчийн халамж анхаарал, зөөгчийн дуулгавартай байдал, суудал алга байсан энэ тэр түүнд огт падгүй ажээ. Танхим дундуур хэсэгхэн зуур явахын хооронд гайхуулах мэт даналзахдаа түүнийг ширтсэн олны харц гуа үзэсгэлэнг нь гэрчилж, Эрикт төрүүлэх гэсэн сэтгэгдлийг нь улам бататгах учиртай юмсанж. Тэрээр аль нэг танил нь таарч хээ шаагүй харилцан гутаах вий гэж болгоомжлон өнөөдөр чухам хэнтэй ярьж хөөрхийгөө өөрөө л сонгож шийднэ хэмээн бодсоор гагцхүү чиг урагшаа тэрхэн зуураа харж өнгөрөв.

Тэгээд ширээний ард суумагц танхим дотуур тоомжиргүй хэрнээ юуг ч эс үлдээх хараа бэлчээж бараан нүдний шилтэй бахимхан япон эртэй цуг сууж буй шар толгойтой бичилхэн бүсгүйд толгой дохив.

–Ноэмийг таньж байна уу?

Мань хүн өнгөрсөн удаа Арбатад тэгсэн шигээ Варятай бас л дотнын найзтайгаа байгаа юм шиг царайлна. Ноэми гэдэг хүний тухай Варя сонсоо ч үгүй билээ. Гагцхүү ганцхан цагийн өмнө Вика түүнтэй “Метропольд” уулзахаар тохирч байхыг сонссоноос цаашгүй билээ.

Дараа ий нэг хөөрхөн хятад хүүхэн рүү заав: – Хараач, Сибилла бас тэнд байна. Зөөгч хутга сэрээ хэрхэн байрлуулж тавихыг Виталий хянах зуураа Сибилла Чен бол Хятадын Гадаад явдлын Яамны сайдын охин, алдартай бүжигчин, маргаашнаас Москвад тоглолтоо эхэлнэ, Ленинградад бас тоглоно, тэгээд дараа нь Европ, Америкийн Нэгдсэн Улсаар тоглолт хийхээр явах юм гэж Варя, Эрик хоёрт тайлбарлав. Тэрээр өөр хэдэн жүжигчний нэр бас нэмж хэлэв. Хагас цагийн дараа тоглолт дуусахлаар гол хүмүүс ирнэ. Арван нэгэн цагаас Утёсовын жааз хөгжим тоглож эхэлнэ. Харин Утёсов ресторанд дуулдаггүй учраас өөрөө ирэхгүй.

Олон охид гадаадынхантай байцгаах ажээ. Цаадуул нь тэдэнд элдэв янз маягтай муусайн новш бэлэглэж, машинаар зугаацуулж байгаад гэрлээд хилийн чанадад аваад явчихдагийг Варя мэднэ. Варя гадаадынхныг эс сонирховч энэ ресторан, усан оргилуур, дуу хөгжим, эргэн тойронд байгаа цуутай хүмүүс энэ тэрийн тухайд бол мань хүн гэрэл гэгээ муутай нийтийн байрнаас чухам энэ мэт юм руу тэмүүлсэн бус уу?

Дарайтал цардсан бүтээлэг, амны алчуур, гялалзаж гялтганасан чамин дэнлүүнүүд, мөнгө, болор... “Метрополь”, “Савой”, “Националь”, “Гранд-отель”... Москвагийн хүүхэн болж төрсөн боловч энэ нэрсийг сонссоноос цаашгүй явсан бол одоо мань хүний ээлж иржээ. Арбатын хорооны ажигч гярхай, сэргэлэн сүүхээтэй охин болохлоор эрчүүд өөрийг нь яажшуухан харж байгаа, хүүхнүүд хэрхэн зэрвэсхэн хяламхийж байгаа энэ тэрийг цөмийг нь сайхан анзаарч авав. Төдийлөн тоомсорлохгүй байгаа нь муу хувцастай болохоор тэр. За гайгүй ээ, энд байгаа олон хүүхнийг дагуулахгүй ганган хувцаслаад ирэхийн цагт та нар шал өөр нүдээр харах вий. Гэхдээ мань хүн ямар замаар гоёлтой болохыгоо огтхон ч бодсонгүй. Тэрээр гадаадынханд биеэ худалдахгүй нь лав, ямар янхан биш. Тэгээд ч энд байгаа хүүхнүүд

цөмөөрөө тийм биш. Нэг ширээ алгасаад түүний цаана байгаа хэдийг хар л даа, дундаа ганцхан лонх юмтай байна, мөнгө байхгүй, зүгээр л бүжиг хийхээр ирцгээсэн хэрэг, мань хүн ч гэсэн өөртөө таарах нөхөд олохдоо л нэг олно.

Дарс сонгоцгоох юм боллоо. Виталий “Шато-и-кем” авах нь зүйтэй гэж зөвлөхөд Вика “Барзак” авна гэж зүтгэв. Варя дарсны нэрийг анх сонсож байгаа нь энэ. Эрик хундага архи, загасны түрстэй авсан нь дээр гэж шийдэв. Тэрээр байнга ялдамхан инээмсэглэх бөгөөд яльгүй харь аялгатай, заримдаа үгээ олж санах гэж хүчлэн байгаа ч гэсэн оросоор дажгүй ярих ажээ. Эцэг нь гэж цууд гарсан утсан харилцуурын фирмийн эзэн швед хүн манай үйлдвэрүүдэд холбооны ямар нэгэн онцгой хэрэгсэл тавьж өгч байгаа, тэгээд инженер хүү нь эцгийнхээ фирмийн төлөөлөгч болж яваа нь энэ юмсанж. Эх нь Орост Балти орчимд төрсөн хүн тул Эриктээ орос хэл зааж сургажээ. Түүгээр ч барахгүй эцэг нь бас орос хэл мэднэ. Тэдний фирм бүр хувьсгалын өмнө Орост анхны утсан харилцуурыг тавьж байсан учраас тэр. Варя инээмсэглээд, скандинавын хүн чинь цэнхэр нүдтэй, хонгор үстэй байх ёстой шүү дээ гэж хэлжээ. Эрик үүнийг үнэмшин үнэн санаанаасаа учрыг тайлбарлав. Түүний ээжийнх нь талын эмэг эх оросын албаны генерал цолтой Балти орчмын гүн хүнтэй суусан гүржийн язгууртны охин байсан гэнэ. Эрик тэр генералынхаа овгийг нэрлэсэнд тэр нь Варягийн таах дуртай таавруудад байдаг нэг нэр шиг санагдав. Тэдний ангид эртний тайж язгууртны овгийн олон ач үрс суралцдаг байсан юм. Тэд нар бол Сивцев Вражек, Гагарин, Староконюшенный зэрэг Арбатын хөндлөн гудамнуудын охид хөвгүүд билээ. Харин Эрикийн удам судар бол эрин зууныг алгасан одсон төдийгүй олон улс орныг дамнан хэрээд тийнхүү эрт цагийн отог омгийг сарниан бутрааж, орчлон дэлхийгээр салаа мөчрийг нь тархаан цацдаг буурал түүх лүгээ адил сонин хачин ажээ.

–Та нар битгий шууд эргэж хараарай, дараа нь харна биз хэмээн Вика ширээ рүү тонгойн аяархан өгүүлээд,

–Бидний ард, зөв гар талаас хоёр дахь ширээнд хоёр хүн сууж байна, нэг итали хүн нэг бүсгүйтэй хамт... гэв.

Цөмөөрөө санаандгүй мэт царайлан ээлж ээлжээр тэр ширээг харцгаав. Тэнд нэг итали хүнтэй хамт өөр гаригийн юм уу гэлтэй жигтэйхэн том нүдтэй, цав цагаан царайтай өндөр туранхай хүүхэн сууж байх ажээ.

–Нина Шереметева гэж Вика зар тараав.

–Нөгөөдүүлийнхнийх үү? гэж Эрик нүдээ бүлтийлгэв.

Эрик тэр хатагтайг сонирхож байгааг Вика анзаараад,

–Тэднийхнийх, гэхдээ жинхэнийх нь биш, доройтож яваагийнх нь гэж хариулав.

–Гэрэл зургийн сурвалжлагчтай сууж байгаад дараа нь нэг жүжигчинтэй суусан юм. Гэтэл тэр жүжигчин нь авгайдаа буцаад оччихсон, одоо энэ итали хүнтэй үүсгэсэн паян нь яаж дуусах юм бол доо гэж Виталий нэмж өгүүлэв.

Тэр хүүхний далан булчирхайг тоочуулах ажлыг Вика өдөөсөн нь илт. Одоо нэгэнт хэрэг бүтсэн хойно мань хүн эв зүйг боддогоо харуулах ёстой гэж үзжээ.

–За, сайхан хүүхнийг тойруулж дандаа хов жив ярьж байдаг шүү дээ.

Гэрэл бүдгэрэн, усан оргилуур дээр хурц гэрэл тусаж, найрал хөгжим хангиналаа. Гонзгойдуу зөв царайтай, өргөн магнайтай, эвлэгхэн самнасан хүрэн халиун үстэй, оготордуу шулуун хамартай, инээмсэглэсэн дөлгөөн нүдтэй, хувилгаан дүртэй гэмээр багавгар чацтай нэг хөвгүүн Варя руу харах ажээ. Костюм, цамц, зангиа, шаахай энэ тэр нь ямар ч өө сэвгүй, ганц ч үрчлээ нугалаа, үс тоос байхгүй, бараг дэндүү цэмцгэр гэлтэй, яг л улаан өндөгний баярын ил захидлын зураг шиг хөвгүүн. Варя түүнийг лав жүжигчин гэж шийдэв. Гагцхүү жүжигчин л ийм сайхан, ийм гоё цэмцгэр байх ёстой. Тэрээр элдэвлэж мурчганаж мурилзахгүй ердийн байдлаар бүжиглэж байгаа нь чухамхүү сүүлчийн маяг тэр билээ. Гэтэл Виталий хуучин маягаар бүжиглэж байв. Нас ахимаг ийм хүнтэй бүжиглэж байгаадаа Варя ичингүйрнэ. Хувилгаан шиг хөвгүүн шижээргүй янзтай бус, зүгээр л “Метропольд” сайхан бүжиглэцгээж байна шүү гэх янзтай өөриймсөг инээмсэглэхийг үзвэл яльгүй хэвлүүн зантай, ресторанаас салдаггүй эр болохоос гадна гадаадсаад байх юм байхгүй, манайхны л жирийн нэг хөвгүүн бололтой.

Хөгжим дуусаж цөм байр байр луугаа явцгаалаа. Нөгөө хувилгаан Варятай зэрэгцэн өнгөрөхдөө түүн рүү дахин инээмсэглэж бүжиг хийсэн эмэгтэйгээ суудалд нь суулгаж өгч талархал илэрхийлээд өөрийнхөө ширээ рүү очив. Түүний ширээ Варягийнхтай усан оргилуурын нэг талд боловч оргилуурт арай ойр ажээ. Тэдний ширээ рүү залуус очиж суухын зэрэгцээ зарим нь босож, бас шинэ хүмүүс ирж суугаад байгаа учраас хувилгаантай чухам хэн хэн байгаа, хэдүүлээ байгааг ойлгохын аргагүй. Тэнд байгаа ганц эмэгтэй нь харваас хөгжилтэй байдаг нүүрэндээ сэвхтэй, аюулын хөөрхөн пандгар бүсгүй бөгөөд хувилгаан тэр хоёр л бүжиг алгасахгүй байв. Пандгар бүсгүй ширээнийхээ аль нэгэнтэй бүжиглэж, хувилгаан янз янзын охидыг урих ажээ. Гэтэл найрал хөгжимчид румба дарж эхлэхэд сайхь хөвгүүн Варягийн ширээний дэргэд ирчихсэн нахисхийн ёсолж, Виталийгаас бүсгүйг нь бүжигт урих зөвшөөрөл хүсэв. Варя хэнтэй бүжиглэхээ өөрөө шийдэх эрхтэй гэж үздэг тул энэ хүсэлтийг рестораны ёс төдий зүйл гэж тооцжээ. Тэрээр босож хувилгааны түрүүнд явсаар бүжгийн тойрогт оров.

Хөвгүүн румбаг яг фокстрот шиг гишгээгээр хийж байв. Варя муухан бүжигчинтэй ч сайхан бүжиглэдэг юм чинь ийм хүнтэй бол бүр ч...

–Би таныг мэднэ хэмээн хөвгүүн инээмсэглэв. Тэрээр цав цагаан шүдтэй аж. Гэхдээ инээмсэглэхэд нь нэг шүд дорсгор гэдэг нь харагдаж байв.

Санаа авахуулах асуулт тавьж санасан хариултаа авч танилцдаг гижигддэг арга хэрэглэх нь. Болхи байна! Мэддэг бол тэр л биз дээ гэх маягийн царай Варя харуулав.

–Таны найзыг Вика гэдэг.

Варя мөн л тоосонгүй. Викаг мэдэхгүй байх алба юу билээ? Түүнийг энд бүх хүн мэдэх байлгүй.

–Танайх Арбатад байдаг хэмээн аанай л нөгөө дорсгор шүдээ сөдийлгөн инээмсэглэж өгүүлэв. Тэгж инээхдээ бүр өхөөрдөм болох аж. Бас дуу хоолой нь сайхнаас сайхан юм.

–Викагийн Арбатад байдгийг мэддэг хүнд манайхыг тааж цөхөх юухан байх билээ.

–Таны өөр бас нэг найзыг Зоя гэдэг.

Хувилгаан тоглож тоглож байгаад сая нэг хожсон хүний дүртэй инээмсэглэн байна.

Варя хөндийрсхийн түүний өөдөөс эгцлэн харав. Энэ чинь ч гижигдсэн буюу тоглоом хийсэн хэрэг биш болох нь ээ. Зоя тэр хоёрыг энэ нөхөр хаана харсан байх билээ?

–Та түүнийг яаж мэддэг юм бэ?

Тэрээр зөндөө юм мэднэ, гэхдээ зүгээр ингээд хэлчихгүй, одоо чи өөрийнхөө тухай тайлах ёстой гэсэн шиг жогтой инээмсэглэх ажээ.

–Миний нэр Лёва, таных?

–Варя.

–Дараачийн бүжигт таныг урьж болохсон болов уу?

–Бололгүй яахав.

Варя Вика, Эрик хоёртой зэрэг ширээ рүүгээ буцаж ирлээ. Виталий бүжиглээгүй, зүгээр сууж байв.

–Варя, түр зугаацаад ирье гэж Вика түүнд хэлэв. Хүүхнүүд уруулаа будаж, оо энгэсгээ тавьж, үсээ янзалцгаагаадаг жорлонг үсчний салбар гэлтэй. Нэг хүүхэн бүснийхээ товчийг хадаж харагдана. Гарын алчуур тавьж өгдөг үйлчлэгч авгайд утас зүү байжээ. Хүүхнүүд түүнд задгай мөнгө хаялж өгнө.

–Энэ чинь юу гэсэн үг вэ? Чи бидэнтэй ирсэн мөртлөө хэн таарсан хүнтэй бүжиглэж байх юм. Ийм юмыг ойлгохгүй байна гэж үү дээ? гэж Вика асуув.

–Виталик зөвшөөрсөн шүү дээ.

–Тэр чинь чамайг урихыг л зөвшөөрсөн, харин чи бол татгалзах ёстой байсан юм. Чи намайг ямар байдалд оруулав. Эрик юу гэж бодох вэ? Хэнд ч татгалздаггүй нэг охиныг улсууд харсан, одоо цөмөөрөө манай ширээ рүү дайрчихна даа.

–Би Виталиктай бүжиглэх дургүй байвал яах вэ?

–Тэгвэл бүжиглэх дуртай хүнтэйгээ л ирэхгүй юу. Нэгэнт бидэнтэй ирсэн бол Виталийтай, Эриктэй бүжиглэ, үгүй ядахдаа бидний таньдаг хүнтэй бүжиглэ. Харин тааралдсан хүн болгонтой бүжиглэнэ гэдэг ч!

–Тэгж ярих юм бол тэр чинь тааралдсан болгон ч биш шүү, тэгж яривал тэр чинь чамайг мэдэж л байна лээ шүү дээ.

–Тийм, тэр намайг мэднэ. Нэрээр мэднэ. Би ч бас түүнийг мэднэ. Лёвочка! Энд түүнийг танихгүй хүн байхгүй, зураг төслийн газрын зурагчин байхгүй юу хэмээн Вика бухимдан ярвайв.

Зояг тэгээд л мэдэж байгаа юм байна, Зоя бас зураг төслийн газар ажилладаг юм чинь. Өөрийг нь ч гэсэн тэнд харж л дээ. Мань хүн Зоя дээр очиж байсан удаатай. Тогтоочихсон байна, шугам зурагчин юм байж, жүжигчин гэж бодсоныг яана. Тэгсэн ч гэсэн яах вэ дээ, өөрөө ч гэсэн шугам зурагчин болох санаатай юм чинь энэ хөвгүүн зурагчин тусмаа л сайн байна.

–Рестораны бүжгийн банди, нэг бильярдчины дагуул байгаа юм, түүнийхээ мөнгөөр ууж иддэг хүн хэмээн Вика үргэлжлүүлж,

— Тэр чамд аятайхан санагдаж байгаа бол дараачийн удаа түүнтэй ирж, тэдний найз нартай бүжиглэхгүй юу, харин өнөөдөр бол намайг амьтны шившиг болгочихгүй хүн шиг байж үз гэв.

Тэднийг танхимд буцаж ирэхэд Эрик, Виталий хоёр босон сандлыг нь дөхүүлэн суулгаж өгөв.

Лёва өөрийнхөө ширээний ард сууж харагдана. Түрүүн цаашаа харж сууж байсан бол одоо наашаа хараад суучихжээ. Тэгээд хөгжим дуугарангуут Варя руу асуух янзтай харав. Мань хүн хариуд нь толгойгоо мэдэгдэх төдий сэгсэрлээ. Лёва өөр ширээ рүү одов. Вика Эриктэй бүжиглэхээр явлаа. Варя Виталийд бүжиг хиймээргүй байна гэж хэлэв.

Энэ оройн явдал нэгэнт замарчээ. Эрикийг үнэн сэтгэлээсээ хөөцөлдөж байж авчирч байхад тэр ачийг яаж хариулна гэнэ ээ? хэмээн Виталий Викад тунирхлаа. Тэрээр шударга гэмгүй хүмүүсийг хувийнхаа эрх ашигт ашигладаг хар амиа бодогчдын тухай бүдэг бадагхан юм үглэж сууна. Вика түүний юу хэлэх гээд байгааг ойлгохгүй царайлна. Харин Варягийн хувьд гэвэл энэ Виталикийн төлөө хумсын чинээ ч санаа зовох юм байсангүй.

Ресторанаас шөнийн гурвын үед гарцгаалаа. Виталий гэртээ очиж пянз сонсохыг санал болгоход Вика нэгд ядарч байна, хоёрт оройтсон байна гэж мэдэгдлээ.

Тэгээд Варягаас,

–Чи яамаар байна? гэж асуув.

–Би аль хэзээний гэртээ байх ёстой.

Эрик өөрийгөө жолооч хэмээн ямар ч тушаалыг биелүүлэхэд бэлэн байна гэв. Виталий машинд суусангүй. Тэрээр энүүхэн Горькийн гудамжинд аж төрдөг тул сайхан алхаад харьчихна. Ийм сайхан орой хайрласанд маш их баярлалаа!

Вика дооглосон янзтай гар даллан салав.

Ерөнхийдөө бол Вика Варягийн тухайд сэтгэл хангалуун үлдэв. Ийм хүнд найдаж болно, өнгөнөөс цаашгүй нүцгэн хоосон толгой биш, сэтгэлийн сэвгүй сайн охин байна, гэнэн томоогүй байдаг нь Викад өөрт нь ч бас нялзах давхар ашигтай, чухамхүү ийм л замын найз хэрэгтэй байгаа юм. Тэр хоёр нэг нь хонгор, нөгөө нь хар үстэй, нуруу тэрсхэн, хоёулаа царайлаг сайхан болохоор харахад ёстой сонгомол хос гэсэн үг, гагцхүү түүнийг хувцсаар нь тордож, үс толгойг нь янзлаад, боловсон зөв ёс сургачихвал болох нь тэр.

Тэд нар Эриктэй маргааш “Национальд” уулзахаар тохирцгоожээ.

Вика Варягаас гадна саяхны нэг уралдаанд нэгдүгээр байрын шагнал авсан, нэртэй уран барилгач найзтайгаа хамт ирэх болов. Эрикт тэр нэр танил байсан тул тэрээр бүр баярлаж орхив.

“Метрополийн” эмс хүүхнүүдийн мөрөөддөг шиг Вика гадаадын хүнтэй сууж, түүнийгээ дагаад явчих бодолтой байсан уу, үгүй юу? Тэрээр энэ тухай хараахан шийдээгүй. Өсөхөөсөө аваад энэ бүхэнд дасаагүй билээ. Хар багаас нь тэдний байранд оруулсан ичих нүүргүй нэг олхиогүй ажилчин тэсэхүйеэ бэрх байжээ. Тэрээр байрных нь үүдний өрөө, гал тогоо энэ тэрд өөрийнхөө дэг журмыг тогтоосон, шөнийн ээлжээс өглөө бууж ирэхдээ халуун усных нь өрөөг шавартай намаг болгочихдог, байрны эзэн эцгийг нь ниргэж гүйцээгүй эсэргүү гэж үздэг нэгэн юмсанж. Гэтэл Викагийн эцэг дэлхийд нэр цуутай профессор хэрнээ ажлынхаа шанд гурил, жимсний чанамал, наалдчихсан мөсөн чихэр энэ тэр авахаас өөр аргагүй, тэгээд буржуй хөрөнгөтөн гэж цуу тарахаас болгоомжлон тэр тухайгаа хүртэл айл хөршийнхөөсөө нуудаг байжээ. Мартагдашгүй хүүхэд ахуй цаг...

Одоо бол бүх юм өөрчлөгджээ. Орон байрыг нь бүрэн буцааж өгсөн, эцэг нь ажлынхаа шанд ой тойнд оромгүй их мөнгө авна, дээд зэргийн хангамжтай, тэднийх алдар цуутнуудын хөлийн газар болжээ. Викад нүүр ам тордох оо будаг, гоёл өмсгөлөөс авахуулаад бүх юм байна. Москвагийн өмнөө барьдаг хөөрхөн хүүхнүүдийн нэг болсон түүний хувьд энэ хотдоо ч гэсэн муугүй л байгаа юм.

Гэхдээ цаашдаа яах вэ? Профессортой юу? Ардын жүжигчинтэй юу? Том даргатай юу? Гэр бүл цүцлах, хүүхдийн тэтгэвэр төлөх... Гэтэл залуучууд дөрвөн зуухан рублиэс эхэлдэг юм чинь хоосноос эхэлж байгаатай адил, зөвхөн хоол хороох хүн гэртээ авчирна гэдэг бол түүний арга барил биш. Харин нисэгч, нисэхийн зохион бүтээгч энэ тэр гээд шинэ дээд төрөлтнүүд бий болж байгаа нь үнэн. Тэднийг Засгийн газар өөгшүүлэн эрхлүүлж сайхан орон сууц, хоол хүнсний зүйл, өндөр цалин өгч байгаа, түүгээр ч барахгүй цалингийнх нь хэсгийг торгсины дэлгүүрээс юм авах тасалбараар өгч байгаа. Водопьянов, Каманин, Доронин, Ляпидевский, Леваневский, Молоков, Слепнёв энэ тэр бол Москвад хамгийн цуутай нэрс. Гэвч энэ нисгэгч нар хаана байна вэ? Бодвол эхнэртэй байлгүй. Энэ ид шидтэй нисэхийн зохион бүтээгч нар хаана байна вэ?

Нэг үгээр хэлэхэд шийдсэн юм алга. Ямар ч атугай япон хүнтэй суухгүй, тэр ч байтугай дэндүү хол учраас америктай ч суухгүй, германчууд бас хэрэг байхгүй, тэнд түгшүүртэй байгаа. Удам угсаа сайтай англи, баян франц, эсвэл хөнгөн хийсвэр итали, өөрөөр хэлбэл Парис, Ром... Шүдэнзний хааны удам швед, нефтийн хааны удам голланд ч байсан бас болно. Тэд нар чинь швед, голланд гэж тооцогддог болохоос биш үнэн хэрэгтээ Лондон, Парист

сууцгаадаг юм. Эрикийн эхнэр болчихвол охидууд агаархаж үхнэ, тэдний хувьд бол ганзагын наймаачин турк л хунтайз гэсэн үг юм чинь.

Ямар ч аугуй ресторанд гагцхүү гадаадынхантай л орох хэрэгтэй, тэгвэл л нэг хүний дайтай байгаага мэднэ, цаадуул нь саймширч зусардан сайхан үйлчилнэ, валютаар авч болохгүй юм гэж байхгүй. Тэрээр маргааш өдөр “Национальд” орно. Дараа нь Эрикийнх руу орох эсэхээ одоогоор мэдэхгүй, Варяг байхад эвгүй байна гээд хэлчихэж болно. Тэгвэл түүний даруухан занг хамгаалахын хамт өөрийнхөө буянтай сэтгэлийг бас харуулчихна.

За ингээд Вика, Варя хоёр “Националь” рестораны авсаархан ширээний ард сууцгааж байна. Тэдэнтэй хамт Эрикээс гадна татавганасан нүүртэй, намуухан дуутай, гучин тав эргэм насны Игорь Владимирович гэдэг нэрд гарсан туранхай уран барилгач байна. Варя түүний тухай радиогоор сонссон ажээ. Вика түүнийг зүгээр л Игорь хэмээн танимхайрна.

Дөрөв дөрвөн хүний жижгэвтэр ширээтэй урт танхим. Зөөгч хүүхнүүд цайгаа өгцгөөж явна. Шилэн аяганых нь тавиур “Националь” рестораны үсгэн тамгатай юм байна. Боов чихрийнх нь таваг мөн тийм аж. Бялуу, дарс. Юм бүхэн ёс төртэй, намбатай, амар жимэр.

Өчигдрийн “Метропольд” байсан хэд хэдэн хүнийг Варя олж харав. Ноэми японтойгоо, Нина Шереметева италитайгаа байх агаад харин нөгөө сэвхтэй пандгар Лёвагүй ганцаараа байв. Хүүхнүүд урт даашинзгүй, өдрийн ахар хувцастай, бас костюмтай хүүхэн олон байлаа. Ноэми мөнгөн аралтай илгэн бүстэй “кардинал” өнгийн костюм өмсжээ. Хантааз нь мөрөн дээрээ мөрдөс шиг түдүүлтэй.

Хөгжим, балетын тухай ярьцгаана. Эрик Стравинский, Дягилев, Павлова энэ тэрийн тухай ярьж, гадаадад аж төрж байгаа оросын хөгжимчид, жүжигчдийг нэрлэн тоочив.

Варя хөгжимд дуртай, охидуудтай консерваторид ордог боловч Игорь Владимирович ямар хөгжимд дуртай тухай түүнээс асуухад,

—Чанга хөгжимд гэж хариулав.

Игорь Владимирович, Эрик хоёр инээд алдчихав. Тэр хоёрыг инээсэн болохоор Вика бас инээж гарлаа.

Хийл, морин хийл, төгөлдөр хуур, бүрээ, цохилуураас бүрдсэн найрал хөгжим тоглож эхлэв. Түүний өмнөх бяцхан талбай дээр бүжиглэцгээдэг аж.

Игорь Владимирович Лёвочка шиг сурамгай биш ч гэсэн сайхан бүжиглэж байв. Тэрээр нэрд гарсан хүн болохоор хүмүүс зүсээр нь таньж тэднийг шохоорхон харцгаана. Нөгөө пандгар Варя руу инээмсэглэж түүнийг таньж байгаагаа ойлгуулав. Бас тэдний ширээнийхэн Варяг анзаарсныг ойлгуулж байгаа нь тэр юм байж.

—Та ёстой сайхан бүжиглэж байна, тантай бүжиглэхэд их амархан байна шүү гэж Игорь Владимирович өгүүлэв.

–Тантай ч бас тийм байна.

Игорь Владимирович нас тогтож төлөвшсөн хүн залуухан бүсгүйтэй байгаа юм шиг цэрвүүхэн байлаа. Гэвч Варя түүнд таалагдаж байгаагаа мэдээд байв.

Вика Эриктэй бүжиглэв. Энэ зуур цаадах нь дараа нь өрөөндөө орохыг урьжээ. Даруй дөрөв дэх удаагаа уулзаж байгаа учир одоо цааш нь сунжруулаад байх арга байхгүй, татгалзана гэдэг бол тооцоо алдана гэсэн үг.

Ийнхүү шийдэхэд Ноэмигийн “кардинал” багагүй нөлөөлжээ. Ийм костюм байх гэж! Гэтэл Викад өөрт нь өлбөнтэй оройн даашинзнаас өөр жинхэнэ хувцас гэхээр юм юу ч байхгүй. Манай дипломатуудын авгай нарын хилийн чанадаас авчирдаг хувцасны загварыг хуулж аваад дараа нь Москвагийн оёдолчдоор хийлгэнэ. Гэтэл тэд нар юу хийж чаддагсан билээ дээ?

Шийдэхгүй бол горьгүй. Өнөөдөр л. Шөнө гэлгүй одоо л сэрэлдээ хөтлөгдөөд орж явчих хэрэгтэй. Тэдний яриа сайхан дөгөө боллоо, юу сонирхдоогоо харуулснаас гадна боловсон сэхээтэн хүнээр гачигдаж гуньж байдгаа илчиллээ. Түүнээс гадна өдрийн цагаар хүний өрөөнд орохыг хэнд ч хориглохгүй.

Гэтэл Варяг яах вэ? Өрөөнд нь дагуулж орчихоод дараа нь явуулах эвгүй юм. Яах гэж үлдсэн нь дэндүү илэрхий юм. Гэрт нь хүргэж өгчихөөд буцаж ирнэ гэхээр тэрнээсээ дор юм болно. Тэрээр эрэгтэйчүүдээ сольж бүжиглэх санал гаргаад тийнхүү Игорьтой бүжиглэх зуур түүнээс Варяг дөхүүлж өгөхийг гуйв.

–Надад оёдолчин дээр очих хэрэг байна. Варя ёстой сайн охин, гэхдээ оёдолчин дээр очихын цагт ямар ч сайн найз байсан тус тусдаа очих нь зүйтэй байдаг юм.

Тэд нар “Националиас” гарцгаалаа.

–Танд зав байвал Александрын цэцэрлэгээр жаахан зугаалах уу? гэж Игорь Владимирович санал болгов.

Цаг нэг их оройтоогүй атал цэцэрлэгийн үүдийг урт сандлаар хаасан байв.

–Энэ сандлыг давцгаая.

Игорь Владимирович сандлын нэг үзүүрийг жаахан арагш нь болгоод мань хоёр төмөр хайс даган, өндөр өндөр далдуу мод, тэгшхэн танасан бутсын хажуугаар бороонд чийгтсэн явган замаар алхлав. Кремлийн ханын сэрэвгэр нуруун дээр шингэх нарны туяа ойн гэрэлтээд одоо хэр харуй бүрий буугаагүй дулаахан сайхан орой болж байв.

–Энүүгээр чинь цагтаа Неглинка гол урсаж байсан юм, тэгээд цөөрөм байгуулж, хожмоо бүр цэцэрлэг болгочихсон юм. Зураг төслийг нь Бове хийсэн, аугаа их уран барилгач хүн гэж Игорь Владимирович өгүүлэв.

–Тийм нэг хүн байсан шүү хэмээн Варя тохуурхах мэт өчив.

Хөгжмийн тухай нөгөө нэг хариулт санаанд нь орсон учир цаадах нь юм хэлсэнгүй.

–Манеж, Бага театр хоёрыг барьсан хэмээн Варя цааш нь өгүүлж,

–Их театрыг түймрийн дараа сэргээсэн, Улсын их дэлгүүрийн нүүрэн тал... Өөр юу байдаг билээ? Ялалтын хаалга, Хотын нэгдүгээр эмнэлэг. Новинскийн цэцэрлэгт гудамжин дахь Гагарин ноёны байшинг барьсан гэв.

–Та яагаад ийм сайн мэдэж байна вэ?

–Би шугам зураг зохион бүтээх чиглэлтэй дунд сургуульд сурч байсан юм. Бидэнд заасан л даа.

–Таны нүдний аньсага яг чамархай руугаа сэртийлгээд тун ер бишийн нүд байна гэж Игорь Владимирович хэлэв.

–Надад татар цусны хольц бий.

–Үгүй ээ, таных бол монгол аньсагатай нүд биш хэмээн цаадах нь зөрж,

–Таных шиг нүд персийн бичил зургууд дээр тааралддаг юм гэв.

–Харин татарын бичил зураг гэж байх биш гэж Варя өгүүлэв.

Хоёулаа инээд алдацгаав.

Дараа нь цаадах нь,

–Та чанга хөгжимд дуртай байдаг нь тоогүй юм даа. Би намуухан хөгжимд дуртай гэв.

–Би сайхан хөгжимд дуртай гэж Варя хариуллаа.

Тээр тэнд манаачийн бараа харагдав.

–Биднийг одоо эндээс хөөх болов уу? гэж Варя асуухад,

–Хэл амаа ололцоно оо гэж цаадах нь зоригтой хариулав.

–Зугтсан нь дээр байлгүй.

Тэр хоёр борооны тогтсон усан дээгуур харайлгасаар үүд рүү гүйцгээлээ. Араас нь шүгэл тасхийв. Гэвч мань хоёр аль хэдийн сандлыг зайчлаад цэцэрлэгээс гараад иржээ.

–Аврагдлаа шүү гэж Игорь Владимирович олзуурхан хэлэв.

Варя өрөөсөн хөл дээрээ догонцон хайс руу налж нэг шаахайгаа тайлав.

–Норгочихов уу? хэмээн цаадах нь түүн руу тонгойв.

–Норгохоос дор юм болжээ. Оймс урагдчихлаа. Тэрээр цорын ганц гайгүй оймсоо ингэчихсэндээ бүр гутарч орхив. Цаадах нь түүнтэй хамт гутран, яах ийхийгээ мэдэхгүй дэмий л дэргэд нь зогсоно.

Тэгснээ өрөөсөн шаахайг нь авч нусныхаа алчуурыг гаргаад гадна дотногүй арчлаа. Бүсгүй цэцэрлэгийн хайсыг түшин зогсоно.

–Та хэдэн размер өмсдөг вэ?

–Гучин тав хэмээн Варя шаахайгаа өмсөөд,

–Одоо дажгүй ээ, хоёулаа явья гэв.

Тэр хоёр зогсоол руу явцгаав.

Варяг трамвайны гишгүүр дээр гармагц,

–Танд утасдаж болох уу? гэж мань хүн асуув.

–Бололгүй яахав.

Төв Хорооны Бүгд хурал зургадугаар сарын хорин есөнд нээгдэв. Гучинд дайрагч отрядын штабын дарга Рем болон тус отрядуудын өдий төдий удирдлагыг алсан тухай мэдээ Германаас ирлээ. Түүхэнд “Урт хутганы шөнө” гэж нэршсэн энэ явууллагыг Гитлер биечлэн удирджээ.

Долдугаар сарын нэгэнд “Правда” болон бусад сонинд энэ тухай өгүүлэл хэдийн нийтэлж амжсаны дотор энэ хэрэг явдлыг фашист дэглэмийн зайлшгүй мөхлийг зөгнөсөн, түүний үхлийн өмнөх цөхрөл хэмээн үнэлсэн Зиновьев, Радек хоёрын өгүүллүүд гарсан байлаа.

Бусдын засаг буурай байвал өөрийн засаг хүчирхэг байгаа нь улам тодордог тул Сталин дээрх үнэлгээг буруушааж эсэргүүцсэнгүй. Гэхдээ мань хүн улс төрийн хөдөлгөөний хагарал тэр хөдөлгөөнийг сулруулдаггүй, харин янз бүрийн талыг баримтлагчдыг тэр хөдөлгөөнд татан оролцуулж, хагалан бутаргагчидтай хийх тэмцэлд гол урсгалыг улам бэхжүүлэн, түүний нийгмийн үндэс суурийг өргөтгөдөг гэдгийг сайн мэднэ. Үүний нэг барим тавин жишээ бол христосын шашин юм.

Ленин засаг төрийн эрхийг авах хүртлээ хагарлаас айдаггүй байсан, харин засгийн эрхэнд байгаа намын дотор хагарал гарахаас болгоомжилж байсан юм. Тэрээр гэрээс гэгдээд байгаа юмыг бичих болсон шалтгаан ч тэр. Ленин төр засгийг энэ засгийг хамгаалан бэхжүүлэхийг сонирхож байгаа хүмүүсийг нэгтгэн нягтруулах хүчин зүйл гэж үзэж байсан. Гэтэл үнэн хэрэгтээ бол хүн болгон засгийн эрхийг өөртөө авах гэж тэмүүлдэг учраас засаг бол задраан бутаргадаг хүчин зүйл. Засгийн эрх хэн ч булааж авч чадахгүй төдийгүй энэ тухай зүрхлэн бодохын аргагүй тийм гарт төвлөрсөн байваас сая тэр засаг нэгтгэн нягтруулах хүчин зүйл болно.

Үүний тулд засаг ялагдашгүй бөх бат гэдэг итгэлийг ард түмэнд бий болгохын хамт энэ засагт халдахаас буцахгүй хэнийг боловч устгах хэрэгтэй.

Ленин өөрийнхөө намыг хувьсгалд хүргэсэн, тэрээр уг намыг өөрөө үүсгэн байгуулсан учраас түүнийг удирдагч байхад эрхэнд нь халдах хүн байгаагүй. Одоо бол байдал өөр. Лениний өвийг залгамжлах тухайд ТҮҮНЭЭС илүү эрхтэй гэж итгэсэн олон хүн засгийн төлөө өрсөлдөж байгаа нөхцөлд МАНЬ ХҮН -СТАЛИН өөрийн засгийг бататган тогтоож байна. Нэгэнт ялагдсан хүмүүс хүртэл горьдлого тасрахгүй байна. Зиновьевыг хар... Ремийг алсан явдал Гитлерийг сулруулаагүй, харин ч хүчирхэгжүүлж байгааг тэр ойлгохгүй байна гэж үү? Ямар улс төрийн бодлогод цоо шинэ хүн биш дээ. Радек гэж нэг залины хөрөнгө бас л ойлгож байгаа. Гэхдээ тэд нар бол аливаа хагарал засаг төрийг сулруулдаг, эсрэг талынхныхаа амь насыг хорооно гэдэг бол зөвхөн фашизмд байдаг явдал, большевизм бол хэрхэвч тэгэхгүй, харин ч өөрийнхөө хүч, эгнээг байнга нягтруулахыг эрмэлздэг гэж намын олон түмэнд үнэмшүүлж итгүүлэх санаатай байгаа юм. Тэд нар тэр хүч нь үү? Улс төрийн бодлогоос аль хэдийн зайлах ёстой байсан сан. Зайлахгүй байна. Олны нүүрэн дээр ил байхын тулд юм бичээд л, энд тэнд үг хэлээд л, байдгаараа тийчилж, цагаа ирэхийг хүлээж, бас дайнаар айлгаж байна! Түүгээр ч барахгүй тэд нар энэ дайныг өдөж байна. Энгельсийн “Оросын хаант засгийн гадаад бодлого” гэдэг өгүүллийг “Большевик” сэтгүүлийн редакц нийтлэх

бодолтой байгааг өөрөөр хэрхэн үнэлэх билээ? Яагаад гэнэтхэн тэгэх болов? Бичигдээд дөчин жил болсных нь хойно? Дэлхийн дайны хорин жилийн ойд зориулах юм гэнэ! Энэ бол “Большевикийн” редакцийн зөвлөлийн гишүүн Зиновьевын болхи мэх, гэтэл ерөнхий редактор Кнорин гэж нэг дүйнгэ толгойт тэр арганд нь орчихсон байгаа юм даа.

Энгельс энэ өгүүлэлдээ Оросын цэргийн хүч оргилдоо тулж байсан аль ч үед Орос орныг Хоёрдугаар Екатерина, Нессельроде, Ливен, Гире, Бенкендорф, Дубельт зэрэг герман голлосон гадаадын авьяаслаг балмад этгээдүүд удирдаж байсан мэтээр нотлон бичсэн юм. Яг одоо үүнийг цохохын хэрэг юу байна? Германчуудыг өргөмжилж, Гитлерийн суртал нэвтрүүлэгт тийм идэш өгөхийн хэрэг юу байна? Оросыг удирдахад орос биш этгээдийн үүрэг роль ямар байсныг онцлохын хэрэг ер нь юу байна? Энэ чинь түүнийг, өөрийнх нь гүрж гаралтайг битүүдээ хэлж байгаа юм биш биз? Зиновьев, Кнорин хоёр өөрсдөө бас орос биш. Гэвч тэдний тухай хэн бодох юм бэ, тэд хэнд хэрэгтэй юм бэ?! Тэгж жиших санаа хэний ч толгойд орж ирэхгүй. Толгойд нөхөр Сталин л орж ирнэ, тэгж л тооцоолсон байх нь. Орос биш этгээд гэдэг санааг жинхэнэ орос хүн Кировт хаяж өгч байна, тухайн үедээ Троцкийг зайлуулахын тулд нөхөр Сталинаар дэнчин тавьсан шиг одоо тэд Кировоор гол дэнчин хийж, түүнд тэр нэг санааг шагнал болгон өргөж байна.

Гэхдээ тэд нар энэ удаа бүр цаашаа, бүр лав явж байна. Яагаад гэвэл тэд нар Энгельсийн өгүүллээс зөвхөн Оросыг удирдахад орос биш этгээд байсан тухай сэдвийг олж үзээд зогссонгүй. Энгельс Оросыг Европын харгис хүчний өмөг түшиг хэмээн нэрлэж тэлэн эзлэх бодлогыг нь буруушаан, Оросын эсрэг ирээдүйд хийх дайныг бараг л чөлөөлөх дайн гэх нь халаг дүрсэлсэн. Яг тэгж л бичсэн: “Германы ялалт, тэгэхлээр хувьсгалын ялалт... Хэрвээ Орос дайн эхэлбэл оросуудын эсрэг, холбоотон нь хэн ч байлаа гэсэн бас тэдний эсрэг урагшаа!” Гэтэл Англи, Герман хоёрын зөрчлийн тухай ганц ч үг алга, уул нь чухамхүү энэ зөрчил л дэлхийн дайны гол хүчин зүйл болсон шүү дээ. Энгельс тэр болгоныг урьдаас олж харж чадаагүй бололтой.

Ингээд бодоход энэ өгүүллийг нийтлэхийн гол утга ийм байх нь: тэд нар ЗСБНХУ-д дайныг хүлээж, одоогийн удирдлагыг унагах хамаг найдлагаа дайнтай холбож, тийм учраас Гитлертэй наймаалцаж зарим нэг буулт хийхэд бэлэн байгаа улс төрийн хүч энд бий гэдгийг Гитлерт харуулах гэж байна. Гадаад улс төрийн бодлогын ялалт байгуулсан мэт байвал тэр нь Гитлерт өс хонзонгоо авах үзэл санааг нь зөвтгөхөд хэрэгтэй. Гитлерт тэд тийм боломж өгөх нь. Гитлерийн хамаг хүч бол өс хонзон авах үзэл санаанд байгаа, чухам тэр үзэл санаагаар үндэстнээ нягтруулж байгаа билээ.

Гэвч зөвлөлтийн ард түмэнд дайн хэрэггүй. Улс орны аж үйлдвэрийн шинэчлэл одоо хэр дуусаагүй байгаа учраас Зөвлөлт Холбоот Улс дайн хийхэд бэлэн биш байна. Дайн тэд нарт, зөвхөн тэд нарт л хэрэгтэй, яагаад гэвэл ТҮҮНИЙГ унагаах өөр арга тэдэнд байхгүй, засгийн эрхийг авах үүнээс өөр замыг тэд үзэхгүй байна. Зиновьев, Радек аман дээрээ Гитлерийн эвлэршгүй эсрэг этгээд мэт байдаг боловч одоо Энгельсийн өгүүллийг нийтлэх гэж оролдсоноороо Гитлерт тус хүргэж, түүний балмад санаархлыг өөгшүүлж, өрнөдийнхөнтэй хуйвалдах нэг муу санаархуу юм түүнд чулуудаж, ТҮҮНИЙ ар хударгаар, ТҮҮНИЙГ золионд гаргасан наймаа бэлтгэж байна.

Сталин нэг цаас авч үзгээ бэхэнд дүрснээ Энгельсийн өгүүллийн тухай Улс төрийн Товчооны

гишүүдэд жижигхэн боловч гаргац сайтай бичгээрээ захидал бичлээ. Тэгэхдээ гагцхүү өгүүллийн утгын талаар л бичив. Зиновьев, Радек, Киров энэ тэртэй холбогдсон хувийнхаа бодол саналыг бичсэнгүй, тэдний нэр усыг ч дурдсангүй. Сталин захидлаа ингэж дуусгав.

“Энгельсийн өгүүллийг “Большевикт” хэвлэнэ гэдэг бол түүний санааг чимээгүй зөвлөмж болгосон хэрэг болох учраас дээр дурдсан бүх зүйлийг харгалзан энэ өгүүллийг манай дайчин хэвлэл “Большевикт” удирдан чиглүүлэх буюу дор хаяхад нарийн сургамжтай өгүүлэл гэж хэвлэх хэрэг байна уу?

Би бол хэрэг байхгүй гэж бодож байна. И. Сталин”.

Дараа нь Сталин үүд рүүгээ очиж Поскрёбышевийн суудаг хүлээлгийн өрөөний хаалгыг нээв. Тэрээр хонхоо ашиглах нь тун ховор, хэрэв Поскрёбышев хэрэг болбол очиж хаалгаа онгойлгоод түүнийг урьж оруулан хэрэгтэй хүнээ түүнд хэлж дуудуулдаг билээ. Поскрёбышев байрандаа байнга байдаг боловч тур зуур эзгүй байвал оронд нь Двинский сууна.

Поскрёбышев сууж л байв. Сталин хананд өлгөөтэй байгаа мэдээний бүртгэл рүү очив. Энэ бүртгэлд хавар бол тариалалт, зун бол ургац хураалт, намар бол бэлтгэлийн ажлын мэдээг өдөр бүр тэмдэглэнэ. Тэрээр мэдээг урьдын адил анхааралтай харсан боловч урьдын адил тэр тухай мөн юу ч хэлсэнгүй. Өрөө рүүгээ буцаж орохдоо Поскрёбышев,

–Ороод ирээрэй гэж хэлэв.

Поскрёбышев араас нь дагаж ороод өрөөний хаалгыг болгоомжтой хааж (Сталин хаалга дутуу хаалттай байхад дургүй, бас ширүүн хаахад дургүй билээ) Сталины яг дэргэд оччихгүй (Сталин бас үүнд дургүй) тэгсэн мөртлөө түүний аяархан дуу сайн сонсох, хэлсэн юмыг нь дахин асуугаад байхааргүй (Сталин хэлсэн юмыг нь дахин асуухад дургүй) дөхөж очиж, ширээнээс нь хэдэн алхам зайтай зогсов.

–Энэ захидлыг аваарай гэж Сталин өгүүлэв.

Поскрёбышев ойртож очоод түүний өгсөн хэдэн хуудсыг гардан авлаа.

–Энэ захидлыг Улс төрийн Товчооны гишүүдэд танилцуулаарай. Захидалтай хамт шийдвэрийн төслийг Товчооны гишүүдэд явуулаарай. Нөхөр Кнориныг “Большевик” сэтгүүлийн ерөнхий редакторын үүрэгт ажлаас чөлөөлнө. Ерөнхий редакторын албан тушаалд нөхөр Стецкийг томилно. Зиновьевыг “Большевикийн” редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнээс гаргаж оронд нь нөхөр Талийг оруулна.

Нөхөр Сталин юм хэлэх төдийд л түүний юу хүсэж байгааг Поскрёбышев яг ойлгоно. Нөхөр Сталин энэ удаад дараах зүйлийг хүсэж байгаа хэрэг: а)Түүний энэ захидал ганцхан хувь чигээрээ үлдэх ёстой, Улс төрийн Товчооны гишүүд уншсаны дараа буцааж авч өөрийнх нь нууцын шүүгээнд хадгална, б) “Большевикийн” редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлтүүд оруулж байгаагийн шалтгааныг Товчооны гишүүд энэ захидлаас олж үзнэ, в)Эдгээр өөрчлөлтийг албан ёсоор тайлбар хийхгүй.

Поскрёбышев,

–Мэдлээ! гэж хариулав.

Гэхдээ гарсангүй. Тэрээр гарах болсон эсэхээ Сталины царайгаар яг мэддэг бас нэгэн чанартай байжээ.

Сталин ширээн дээрээс улаан хүрэн савхин хавтас авч Поскрёбышевт өгөв.

–Шуудан аваарай.

Одоо гарах ёстойг Поскрёбышев мэдэх учир хэсэг ухарснаа эргэж өрөөнөөс гарч хаалгыг мөн л болгоомжтой сайн хаав.

Тэрээр ширээнийхээ ард тухлан сууж Сталины эргүүлж өгсөн савхин хавтастай шууданг хянаж үзэв.

Хамгийн гол зүйлийн шууданг нөхөр Сталинд илтгэдэг билээ. Чухал юмыг чухал бус юмнаас, хэрэгтэй юмыг хэрэггүй юмнаас ялгаж чаддаг нь Поскрёбышевийн бас нэг сайн чанар юм. Сталины нэр дээр ирдэг бүх шууданг тэрээр ганцаараа уншиж гүйцэхгүй нь мэдээж, ерөөсөө л чадал хүрэхгүй, энэ ажлыг нарийн бичгийн дарга нарын газрын тусгай хүмүүс хийж, шууданг нь ангилж ялгаад, чухал гэж үзсэн зүйлээ Поскрёбышевт дамжуулна. Чухамхүү тэр дотроос л мань хүн илтгэх хэрэгтэй гэж үзсэн зүйлээ сонгож авна. Нарийн бичгийн дарга нарын газрын хүмүүс ажлаа ойлгодог учраас юу шаардлагатай, тухайлбал Төв Хорооны гишүүд ялангуяа Улс төрийн Товчооны гишүүдтэй холбогдсон захидлыг заавал илтгэх ёстойг мэднэ. Поскрёбышев өглөө бүр шууданг нөгөө улаан савхин хавтсанд хийж нөхөр Сталины ширээн дээр тавьдаг бөгөөд өнөөдрийнх шиг Сталиныг өөрийг нь өгөхлөөр буцааж авна.

Поскрёбышев эргүүлж өгсөн шууданг нөхөр Сталины үзэг хүрсэн захидлууд, үзэг хүрээгүй захидлууд гэж урьдын адил хоёр хэсэг хуваав. Нэгдүгээр хэсгийг нь тэр даруй нарийн бичгийн дарга нарын газар өгч, тэнд тэдгээрийг нь бүртгэж аваад Сталины цохсон дагуу гүйцэтгэх ёстой. Хоёр дахь хэсэг буюу дээр нь ямар ч цохолт байхгүй захидлуудыг бүртгэж барилгүй нөхөр Сталиныг шаардаж үзтэл нь нууцын шүүгээнд хадгална.

Гэтэл бас нэг бүлэг захидал бий. Тэр бол Сталин шууд буцааж өгөөгүй буюу заримдаа огт буцааж өгөлгүй өөртөө хадгалдаг захидлууд бөгөөд тэднийг устгачихдаг явдал ч бий. Энэ бол онцгой ач холбогдолтой захидлууд юм.

Поскрёбышев өглөө нөхөр Сталины ширээн дээр шууданг тавихдаа захидлуудыг дахин тоолж, тоог нь тэмдэглэж авдаг аж. Сталинаас шууданг буцааж авмагц мөн тоолж үздэг тул тийнхүү Сталин хэдэн захидал өөртөө үлдээснийг мэдэж авна. Чухам ямар ямар захидал үлдээснийг ч бас мэднэ. Тэрээр бичиг цаасны тухайд тун ой сайтай, өглөө Сталины ширээн дээр шууданг тавихдаа доторх зүйлийнх нь агуулгыг баримжаагаар тогтоочихно.

Энэ удаа Ягодагийн мэдээлэлтэй битүүмжилсэн дугтуйнаас бусад бүх захидал хавтсандаа эргэж иржээ. Тийм битүүмжилсэн захидлыг Сталин ерөөсөө өөртөө үлдээдэг юм.

Марк Александрович Төв Хорооны Бүгд хурал яг нээгдэх өдөр, зургадугаар сарын хорин есний өглөө Москвад ирээд, долдугаар сарын нэгний орой бүгд хурал дуусангуут яваад өгчээ. Яарчээ. Цувих суурь машиныг ашиглалтад оруулах гэж байсан бөгөөд тийнхүү оруулснаар үйлдвэр нь төмөрлөгийн үйлдвэрлэлийн хувьд бүтэн орчилтой үйлдвэр болох юм. Марк Александровичийн энэ насны гол ажил болсон дэлхийд дээгүүр орох аварга том төмөрлөгийн үйлдвэр байгуулах ажил тэгээд дуусна.

Марк Александрович бүгд хурлаас хөндийрсөнгүй. Үр тариа, мах нийлүүлэх, мал аж ахуйг сайжруулан хөгжүүлэх тухай хэлэлцсэн асуудал нь намын эдийн засгийн бодлогын нэг хэсэг учраас мань хүн эдийн засгийн нэг удирдагчийн хувьд энэ бодлогыг тал бүрээс нь мэдэж байх ёстой билээ. Гол зорилт болж байгаа цувих суурь машиныг ашиглалтад оруулах ажил Москвагаас хамаарахаа хэдийн больж гагцхүү үйлдвэр дээрээ шийдэгдэж байгаа учраас тэрээр Ардын комиссарын газраар хүртэл орсонгүй.

Харин Марк Александровичийн бүгд хуралд хамаарахгүй ганц ажил нь Соня эгчтэйгээ уулзах явдал байжээ. Саша ял шийтгүүлж цөлөгдсөн, одоо түүнд туслах ямар ч арга байхгүй. Ял заахаас нь өмнө хөөцөлдөөд тус болоогүй юм чинь Онцгой зөвлөлгөөнөөс заасан ялыг давж заалдах эрх байдаггүй болохоор одоо яаж ч хөөцөлдөөд бүр нэмэр болохгүй. Сашагийн талаар мань хүн, Төв Хорооны орлогч гишүүн Рязанов хөөцөлдсөн гэдгийг дээш нь хамгийн дээд цэгт нь хүртэл илтгэсэн байх нь маргаангүй зүйл, гэтэл Саша ял заагдсан байхыг үзэхүл ямар нэгэн хэрэгт холбогдсон байж таарна. Гэхдээ энэ бол сөнөсөн сүйрэл биш. Саша залуу хүн, гурван жил дорхноо өнгөрчихнө, амьдрал нь хүлээж байна.

Гэлээ ч гэсэн Сашагийн тухай бодол Марк Александровичийн сэтгэлийг зовоогоод байлаа. Амьдралд нь төвөгтэй юм аль байсныг тэр гэх билээ, гэхдээ энэ талаасаа бол хэзээ ямагт бүх юм цэв цэвэрхэн, тов тодорхой, яг номоороо байсан, өөрт нь ч гэсэн, ойр дотнынхонд нь ч гэсэн элдэв нугалаа, бүлэглэлийн зүгийн юм огтхон ч байгаагүй. Тэрээр улс төрийн бодлогод оролцож яваагүй гэр бүлд өсөж бойжсон, тэднийхээс ганцхан Марк л өөрөө намын гишүүн. Эгч нар нь цөм нам бус, тэд нарынх нь нөхөр мөн адил. Сашаг л намын гишүүн, коммунист болно гэж бодож явсан. Гэтэл Сашад ийм явдал тохиолдчихсон байдаг! Рязановын өөрийнх нь зээ дүү тавин наймдугаар зүйл - хувьсгалын эсэргүү суртал ухуулга хийсэн хэргээр яллагдчихжээ! Марк Александрович өөрөө анзаарга анхааралгүй байж байгаад ийм болгочихож гэхээс намын өмнө гэм буруугаа ухааран байв. Энэ бол өөрт нь толбо. Яг хувьсгалын дараахан ийм болсон бол энэ ойлгомжтой байх байсан. Хувьсгал нэг бус гэр бүлийг хуваасан юм чинь. Үгүйдээ хориод онд ийм юм болсон бол бас тайлбарлаж болох зүйл. Хориод он бол удирдлага солигдсон жилүүд, нугалаа, эсрэг хүчнүүд гарч ирсэн жилүүд, залуучуудын нэг хэсэг, ялангуяа суралцаж байсан залуучуудын нэг хэсэг нь Троцкийн хоосон цэцэрхлийг шохоорхон дагаж байсан үе. Гэтэл одоо гучин дөрвөн онд, нугалаа, эсрэг хүчнийхэн энэ тэрийг үүрд устгаж, намын шинэ удирдлага батжин тогтож, намын жанжин шугам тогтворжоод, нам, ард түмний дунд хэзээ ч байгаагүй нэгдэл нягтрал ноёрхож байхад Сашад тохиолдсон зүйл бол мань хүн дээр ч гэсэн хар толбо хаяж байгаа жигшүүртэй муухай явдал.

Сашад юу дутаад байсан юм бэ? Москва, орон байр, сургууль, сайхан ирээдүй гээд бүх юм түүнд байсан. Тоо бүртгэлийн багштай зөрсөн хэрэг, ханын сонин хоёроос болж шоронд хийхгүй, тэглээ гэж хэдэн жил өгөх ёсгүй. Тэгэхлээр ямар нэг юм байсан болох нь, хүн нуусан байж таарах нь. Хэн нэгний нөлөөнд автав уу? Гэтэл ямар нялх хүүхэд биш дээ, хорин хоёртой том хархүү, дотроо бодолтой байх ёстой! Гэхдээ зөвхөн өөрийнхөө тухай ч биш, ээжийнхээ тухай сонсох ёстой. Эцгийг нь орлож өсгөсөн нагац ахынхаа тухай, энэ бүхэн ахад нь, түүний байдалд, нам, улсын өмнө хүлээсэн нэр алдарт нь яаж нөлөөлөх вэ гэдгийг бодсон ч болох л зүйл. Бодсонгүй! Тоосонгүй! Яагаад тэр вэ? Ухаантай хүн болж байгаа нь тэр. “Аль болохоор даруу байвал зүгээрсэн” гэж тэр муу амных нь заваан арилаагүй банди Сталины тухай ярьсан гэж байгаа, Сталин ямар байх ёстойг ярьж байх юм гэнэ! Марк Александровичийн үйлдвэрт арван нэгэн мянган охид хөвгүүд, комсомолын гишүүд бий, тэд нар ажил хийж байгаа! Хоёрдугаар домна зуухыг барьж байхад тэд нар хөхөө өвлийн хүйтэн, хөр цасны жаварт хагас, бүтэн сайн гэж мэдэхгүй хоногт арван зургаан цагаар ажиллаж байсан. Түүнийг Москвагаас эргэж ирэхэд (Оржоникизе түүнийг хэд хоногоор дуудсан юм) элс, хайрга, цемент вагон дотроо барилдаж хөлдчихөөд байгаа тухай илтгэж байсан. Гэтэл зуурмаг бүлээн байх ёстой. Тэгэхэд өчигдөрхөн хөдөө тосгоноос ирсэн тэр охид, хөвгүүд уурын тэрэгнүүд тавьж, төмөр хоолой татаад түүгээрээ өдөржин шөнөжин уур, халуун ус гүйлгэх аргыг нь олсон доо, тэр хоёрдугаар зуухыг комсомолын нэрэмжит болгуулахын тулд ингэж л ажиллаж байсан юм! Хоол ундаа яг тэндээ задгай гал дээр л хийцгээнэ. Морьд нь шаварт зоогдон, түрдэг тэргэнцэрүүд дамнуурган зам дээрээс мултарч үйлээ үзэцгээнэ, гол зэвсэг нь хүрз, гол тээвэр нь морин тэрэг, ухаад барагдахгүй суурийн нүх, зөөгөөд гүйцэгдэхгүй газар шороо, тэнгэрт тулсан тоосон манан, чих дөжирсөн дуу шуугиан ийм л учир нь олдохын аргагүй юман дотроос орчин цагийн аварга үйлдвэр боссон юм. Тэгэхэд энэ залуу хүмүүс, энэ урам зориг нь бадарсан багачуул биеэ хайр найргүй зүтгэснээс биш бэрхшээл зовлонгийн тухай үглэж байгаагүй билээ. Тэд Арбатынх шиг тохилог сууцанд тухлаагүй, майхан, газар байр, түр банзан байшин мэтийн оромжинд нэг ам бүл ганц ор, өвс чихсэн ганц гудсан дээр хоног төөрүүлж байсан. Үзээгүй юм гэж байхгүй. Бөөс, нохой бөөс, жоом, балнад... Багшийн хүрэлцээ муу, нөгөө унтдаг түр байшиндаа л хүүхдүүд хичээл хийнэ, гадаа задгай газар кино гаргана, саравчин дотор дэлгүүр ажиллуулна, дэлгүүрт нь юу байна вэ? гэхлээр хоосон тавиурууд. Гавшгайчуудыг өмд, банзал эсвэл шаахай авах бичгээр, аягүй бол жижигхэн хайрцаг мөсөн чихрээр шагнана. Тиймхэн шагналаараа ч гэсэн бахархацгаадаг байлаа. Тэд нар социалист хүнд үйлдвэрийн бат цайз байгуулж улс орныхоо хэдэн зууны хоцрогдлыг арилгаж батлан хамгаалах хүч чадал, эдийн засгийн тусгаар тогтнолыг нь бэхжүүлж, шинэ социалист нийгэм барьж байгаагаа ойлгоцгоож байсан юм.

Тэр охид, хөвгүүдийн ойлгож байсан юм энэ. Тэд нар нөхөр Сталиныг юухнаар ч буруутгахгүй. Сталин бол тэдний аж амьдрал, тэдний зүйрлэшгүй хөдөлмөрийн бэлэг тэмдэг. Тэд нар, тэр охид, хөвгүүд түүхийг бүтээж байгаа болохоос биш шорон, Сибирийн цөллөг хүртэл шалдаа буусан түүний зээ Саша мэт нь түүхийг бүтээж байгаа бус болой.

Марк Александрович эгчийнхээ, нүдэнд ижил дасал болсон байшин руу хүрч ирлээ.

Уг барилгын нүүрэн тал гялгар паалантай цагаан хавтангаар өнгөлөөстэй, “Арбатский Арс” кино театрын дээр тод тод зарлал нь салхинд дэрвэгнэж, ойрхон барьсан барилгуудын завсрын ангал шиг хороонд Саша тоглох нь элбэг, тэгээд өөдөөс нь мөгзгор гараа сарвайсаар

гүйж ирж, дээшээ гэр лүүгээ хамт очиж “Марк ах ирлээ, ура!” хэмээн бүх “р”, “л”-ийг тов тодхон хэлж чанга хашгирдаг сан.

Орчлон эрээнтэй бараантай, хүн амьтанд гай зовлон заяасан байдаг нь үнэн юм даа, одоо Соняг гай түүтгэр нөмөрчихөөд байна. Хамгийн номой халирхай, хамгийн өмгөөл ивээлгүй эгчээс нь нөхөр нь явчихсан, одоо хүү нь цөлөгджээ. Тэрээр эгчийгээ өрөвддөг боловч Павел Николаевич түүнийг хаяад явах үед ямар ч тус болж чадаагүй, одоо бас тус хүргэх ямар ч аргагүй байв.

Тэрээр эгчийгээ өрөвдөж хайрлах, хэдэн мөнгөөр тус болохоос цааш гарах чадалгүй ажээ. Эрэлхэг зоригтой, хагуу тэвчээртэй байх хэрэгтэй. Үүрдийн зовлон гэж байхгүй, зовлон өнгөрдөг зүйл.

Тэрээр хамгийн сүүлд эгч дээрээ ирэхэд ямар байсныг саналаа. Царай нь чичрээд ямар өрөвдөм байсан, өөрт нь яаж саймшран, элдэв бичиг цаасаа уймран хайж, яаж тэр цааснуудаа чичирхийлсэн хуруугаар толийлгож байлаа! Марк Александрович гэрт нь ороогүй байж л хүзүү шил руу хөшилдөж янгинаад явчихав. Дахиад л эгчийнхээ горьдлого хурсан нүдийг харна, бас энэ харцанд нь нөгөө горьдлого нь талаар болно хэмээсэн айдас давхар хурсан байгаа. Сашад яаж ч туслахын арга байхгүй, үүнийг ойлгож, эвлэрэх цаг одоо болсон. Саша гурван жилийн дараа л гэртээ ирнэ.

Софья Александровна тун сая ажлаасаа ирээд хоолоо халааж байв. Түүнийг үзээд хуучин шигээ баяр хөөр болсонгүй, дөлгөөхөн мэнд амар мэдэлцэв. Эгч нь хуучин түүнийг ирнэ гэж бэлтгэж, бялуу хайрч, өөрөө хувцас хунараа сольж хэрхэндээ гоёдог байсан бол өнөөдөр Марк Александрович өдөр болгон ажилдаа явдаг, тийм учраас элдэв бялуу, идээ будаатай манатай ганц бие авгайн гэрт иржээ. Софья Александровна дүүтэйгээ мэндлээд, өөрийнхөө идэх гэж буй хөцтэй шөл, тосонд шарсан төмс, давсалсан махнаас түүнийг иднэ гэж дотроо эс итгэвч цуг хооллохыг санал болгов. Марк Александровичийн авчирсан ууттай юм, бас цүнхнээсээ гаргасан боодолтой юм энэ тэрийг төдий л хайхарсангүй. Эгч нь ажилд орсон нь сайн болж, бүр өөр хүн болчихсон байна гэж Марк сэтгэл ханамжтай бодов. Эгч нь хуучин айлын авгай, хүүхдийн ээж, гэрийн эзэгтэй л байж билээ. Одоо бол ажлын мөр хөөж, хамт олны дунд орсон болохоор гэр орны ажлаас гадна санаа тавих юмтай болж, сэтгэлийн зовлонгоосоо хөндийрөн, нүд нээгдэж, тогтвор, зориг тэвчээр суужээ.

Марк Александрович эгчтэйгээ уулзахлаар сэтгэлийн бөөн зовлон болно гэж эмээж байсан учир одоо байдал өөр байгаад эгчийнхээ өмнөөс ч, өөрийнхөө өмнөөс ч баяртай байв.

Гэхдээ эгч нь Маркийн итгэж байгаачлан шинэ сайхан чанар эзэмшсэн боловч хар бага наснаас төрөлх дотно болсон уяхан намбалаг, өрөвч цайлган сэтгэл нь алга болсон мэт байхыг тэрээр өр зүрхнээсээ мэдрэхгүй байж чадсангүй. Гэр нь цэмбийж цэвцийгээд сэтгэл хоргодом тавлаж тухлан тохилог байдгаа больчихжээ. Хэрэгтэй хэрэггүй хөөрхөн юмнууд нь ч алга. Одоо яаруу сандруу, босоо суугаагийн завсар аж төрж байгаа учраас зөвхөн зайлшгүй шаардлагатай юмс л үлджээ. Сараалжин төмөр тавиур дээрх хайруулынхаа тавагнаас л төмсөө шууд идэж байв. Ширээнийх нь бүтээлэг нэг буландаа нугарчихсан харагдана. Гэхдээ эгч нь хэнээ алдаж шалдаа буугаагүй, харин ч болбоос биеэ өөд татаж, тарга нь шуугдан, хөдөлгөөн нэмэгдэж ажил хэрэгч болжээ. Өөрийнх нь хувьд гэр нь ердөө утга учиргүй зүйл

болчихсон бололтой. Нэгэнт хүү нь байхгүй юм чинь.

Тэрээр угаалгынхаа газрын ажлын тухай ярив. Цагаан хэрэглэл хүлээн авагчийн ажил бол гайгүй ажил. Мэдээж яршигтай хүн тааралдана. Гэвч одоо чинь хүн амьтан цөм уцаар унтуу болчихсон хойно яая гэх вэ дээ. Хүний юмыг муудуулах, гэж үрэгдүүлэх мэтээр үйлдвэрлэлийнхээ талаас ч зөрчил гаргах явдал бий. Тийм хэрэг гарвал учрыг олох, тайлбарлах, бичиг цаас бүрдүүлэх гээд тун төвөгтэй, гэтэл оочерт хүлээж байгаа хүмүүс дургүйцэн шуугилдана. Хүлээн авагч хүнээ ажлаас нь хөндийрүүлэхгүйн тулд зөрчилтэй асуудлын учрыг эрхлэгч нь олох ёстой, гэтэл тэр нь гарч ирэхгүй, ерөөсөө ажил дээрээ байна гэж байхгүй, өдөржин хаагуур ч юм бэ тэнээд алга болчихно, юу хийж явдаг нь сонин баймаар. Эгч нь хэзээний тоглоом шоглоомд дуртай, одоо ч гэсэн тоглоом хийхтэйгээ байгаа аж.

Гэтэл Сашагийн тухай хүний урманд ганц үг дуугарсангүй. Дуугүй суухгүйн тулд ёс бодож л юм ярьж байгаа нь илэрхий. Өөрийнх нь нүүр рүү харахгүй, хараа мөргөлдөхөөс бултаж байхыг үзээд зориуд хэлэх гэж зэхсэн үг байгааг Марк мэдрэв. Эгч нь тэр үгээ хэлэхдээ л нэг хэлнэ. Харин одоохондоо тээнэгэлзэн, бас харцнаас нь зайлсхийгээд байгаа нь аргагүй хуучин Соня дүрээрээ мөн.

Тэрээр нөгөө ярьж байсан юмаа гэнэтхэн тасалж,

–Өө тийм, би чамд урьдаас хэлэх ёстой юм байна, би жижиг өрөөндөө хүн суулгаж байгаа. Тийм учраас чи манайд хонох болбол миний энд л хононо шүү дээ гэв.

–Би зочид буудалд буусан гэж Марк Александрович хариулав.

Эгч нь хоёр дахь өрөөгөө хураалгаагүй үлдээж чадсаныг тэрээр мэдэх билээ. Павел Николаевич тэр хоёр албан ёсоор салаагүй, тэгээд Сашаг баригдсаны дараа нь Николаевич орон нутагт түр хугацаагаар явсан (хүний хувьд орон сууцныхаа талбайг тэр хэвээр нь нэр дээрээ байлгахгаар шийдүүлж дөнгөсөн юм. Харин эгчтэйгээ нэг өрөөгөө хөлслүүлж байгаа гэж дуулаад тэр хүн ер баярласангүй. Өрөөний хөлсөнд орон сууц төлбөрөөс илүү мөнгө авч болохгүй, тэгэх юм бол сууцаар дамын наймаа хийсэн хэрэг болно. Одоо зун сууцны хямрал болж, хүмүүст толгой хоргодох зар олдохгүй байгаа учраас өрөө хөлслүүлэх зэргийг их тоохгүй буй нь үнэн боловч Маркийн хувьд өөрийнхөө эгчийг, мань Рязановын эгчийг өрөө хөлслүүлж амь зуулгамааргүй санагдав. Тэрээр эгчдээ мөнгөөр туслахаас хэзээ ч татгалзаж байгаагүй, одоо тэр өрөөний хөлсөнд авч байгаагаас хавьгүй их мөнгө өгч чадах билээ.

–Заавал тэгэх шаардлага байсан юм уу?

Эгч нь ойлгосонгүй.

–Яах шаардлага?

–Өрөөгөө хөлслүүлэх?

–Тийм, надад мөнгөний хэрэгцээ байна.

–Хэдийг төлдөг вэ?

–Тавин рубль.

–Ямар хүн сууж байгаа юм?

–Эмэгтэй. Нэг хижээл авгай.

–Танайхыг яаж мэдээв?

–Манай айлын хүмүүс зөвлөсөн юм... Юу гэж? хэмээн тэрээр сая нэг өөдөөс нь эгцлэн хараад, –Би буруу юм хийсэн гэж чи үзэж байна уу? гэв.

–Чи тэр авгайг мэдэхгүй... Айлынхан зөвлөсөн юм гэнэ шүү... Ингэх ямар хэрэг байна вэ? Байрны захиргаагаар орж бүртгүүлэх гэж хөөцөлдөх, яасан ийснээ учирлах... Ямар хэрэгтэй юм бэ? гэж дахин хэлж байна. Би чамд сард тавь биш, зуун тавин рубль өгье. Би таван зуун рубльтэй ирсэн. Надад мөнгөний хэрэг байхгүйг чи мэднэ шүү дээ.

Цаадах нь чимээгүй юм бодож байснаа,

–Би чиний мөнгийг авахгүй. Би амь зуух мөнгөө ажил хийж олж байгаа, миний хувьд бол хэрэг байхгүй. Харин Сашагийн хувьд гэвэл... Сашад эцэг ч бий, эх ч бий, тэд нар нь санаа тавих болно гэж тайван өчив.

Түүнтэй зөрөөд дийлнэ гэж байхгүй, мань хүн ч зөрье гэсэнгүй. Тэрээр мөнгө өгье гэлээ, гэтэл эгч нь өрөөгөө хөлслүүлсэн нь дээр гэж үзэж байна, өөрөө л мэдэх хэрэг, дүү нь дургүй байгааг харсан хойно яая гэхэв. Тэгээд саяхны хэлсэн зүйл бол нөгөө зэхсэн үг нь бас биш, ингэж нуугдаж тоглож байгаа юм шиг байхын хэрэг алга. Бушуухан хэлээсэй.

–Саша яаж байгаа вэ? гэж Марк Александрович асуув.

Эгч нь тэр даруй хариулахыг завдсангүй.

–Саша... Сүүлчийнх нь захиа Канскаас ирсэн Богучаны гэдэг гацаанд очих ёстой юм, гэтэл тэндээс одоо хүртэл юу ч алга. Тийшээ явган явсан юм уу, унаагаар явсан юм уу, бүү мэд. Би газрын зургаас харсан... Богучаны Ангара мөрөн дээр байна, харин тийшээ очих зам гэж ерөөсөө байхгүй, бодвол явган явсан л байх гэснээ гэнэтхэн мушилзаж –Одоо тамлах ажилд яаж хөөж аваачдагийг мэдэхгүй юм, хуучин бол Столыпиний вагоноор аваачдаг байсан, одоо чухам яадгийг даанч мэдэхгүй юм... гэв.

–Соня! хэмээн Марк Александрович нухацтай өгүүлж –Чамд их хэцүү байгааг би ойлгож байна. Гэхдээ чамайг юмны байдлыг тодорхой мэдэж байгаасай гэж би хүсэж байна. Нэгдүгээрт, манайд тамлах ажил гэж байхгүй. Хоёрдугаарт, Сашаг хориход явуулсан биш цөллөгт явуулсан. Би бүр дээд байгууллагуудад асуудал тавьсан. Тэд оролцсон боловч юу ч хийж чадсангүй. Хууль бол хууль шүү дээ. Сашад ямар нэг хийсэн хэрэг байгаа, бодвол нэг их сүртэй хэрэг биш байх, гэхдээ л байгаа. Бид хатуу ширүүн үед амьдарч байна, яах ч арга байхгүй, түүнийг гурван жилээр цөлсөн, энэ хугацаанд хөдөө амьдарна, хөдөө чинь сая сая

хүн аж төрж байгаа, мань хүн тэнд ажилд орно. Залуу хүн юм чинь гурван жил дорхноо өнгөрчихнө, харин нэгэнт зайлшгүй болсон юмтай эвлэрэх л хэрэгтэй, өөрийгөө уруу татаад байлгүй тэвчээртэй тайван хүлээх хэрэгтэй гэв.

Эгч нь гэнэтхэн инээмсэглэснээ больж дараа нь дахиад инээмсэглэв. Тэрээр энэ инээмсэглэлийг сайн мэдэх билээ.

Тэгээд эгч нь ингэж өгүүлэв:

–Тэгэхлээр багадуулсан болох нь ээ, дөнгөж гуравхан жил.

–Илүү өгөх ёстой байсан юм гэж би хэллээ гэж үү дээ! Соня, сэрээч! Нууж хаах юу байх вэ, энэ чинь манай үед өчүүхэн зүйл, гурван жилийн цөллөг гэдэг чинь... Буудаж алаад л байгаа шүү дээ...

Эгч нь юу юугүй инээд алдах нь уу гэлтэй инээмсэглэн байв.

–Өө тийм бий... Буудаж алсангүй... Ханын сонинд бяцхан шүлэг бичлээ гэж буудаж алсангүй, Сибирьт дөнгөж гуравхан жилээр цөлж. Их баярлалаа! Гурван жил, яриад байх юм биш, яльгүй зүйл! Иосиф Виссарионовичид ч гэсэн гурван жил цөлөхөөс илүү ял ноогдуулж байгаагүй юм чинь. Гэтэл тэр чинь зэвсэгт бослого, ажил хаялт, жагсаал зохион байгуулж, нууц сонин гаргаж, хулгайгаар хил давж байхад түүнд ялгаагүй л гурван жил өгч байсан, цөллөгөөс оргоход нь барьж буцааж аваачаад мөн л гурван жил өгсөн. Харин Саша одоо орголоо гэж санавал их сайнаар бодоход түүнд арван жилээр хорих ноогдуулна... гэснээ Софья Александровна инээмсэглэхээ больж, Марк Александрович руу эгцлэн ширүүн хараад, –Мөн дөө! Хэрвээ хаан та нарыг танайхны хуулиар шийтгэж байсан бол дахиад лав мянган жил ширээндээ байх байсан даг аа... гэв. Марк ширээ шаалаа.

–Чи юу бурж байна вэ? Тэнэг толгой! Хаанаас чи ийм юм сонсоо вэ? Дэмий ярихаа одоохон боль! Ийм юм ярихаасаа зовохгүй байна уу? Миний дэргэд шүү! Бид диктатуртай нь үнэн, диктатур гэдэг чинь хүчирхийлэл. Гэхдээ олонхи нь цөөнхөө хүчирхийлж байгаа юм. Харин хааны үед бол цөөнх нь олонхио дарангуйлж байсан юм. Тийм ч учраас бидний одоо ард түмний тусын тулд, ард түмний төлөө хэрэглэж байгаа эцсийн аргыг хэрэглэж зүрхлэхгүй байсан юм. Хувьсгал бол өөрийгөө заавал хамгаалах ёстой, гагцхүү тэгж баймааж нь сая нэг юмны дайтай болно. Чамд маш их зовлон учирсан, тэглээ гэж чи бэртэгчин болох ёсгүй. Чи юу ярьж байгаагаа огт бодохгүй байна. Чи хэн нэгэн хүнд ийм юм ярих юм бол шоронд орно гэж мэд. Чи үгүйдээ Сашагаа бодсон ч үүнийг бодолцох хэрэгтэй. Саша одоо эхээсээ хагацах ёсгүй шүү.

Цаадах нь чимээгүй сонсох зуур ширээн дээрээс хурууныхаа өндгөөр талхны үртэс тэмтрэн олж няцалж байв. Тэгснээ тайван гэгч нь,

–За Марк, тэгэхлээр... Манай гэрт хэзээ ч ширээ шааж авахгүй байхыг чамаас гуйя. Энэ чинь надад эвгүй байна. Түүнээс гадна надад айл хөршийнхөн гэж байна, тэдний өмнө ч гэсэн надад эвгүй байна. Урьд нөхөр маань над руу ингэж ширээ балбадаг байсан, одоо дүү маань балбаж байна. Дахиад хэзээ ч битгий ингээрэй. Хэрвээ чамд ширээ балбамаар санагдаад

байдаг юм бол албан тасалгаандаа доод ажилтан нар луугаа тэгдэг юм байгаа биз. Үүнийг тогтоож аваарай. Шоронгийн тухайд гэвэл намайг сүрдүүлэхийн хэрэггүй, надад айх юм байхгүй, айдгаа айж гүйцсэн, одоо болоо! Бүх хүнийг та нар суулгаж чадахгүй шүү, шорон чинь хүрэхгүй... өчүүхэн бага хэсэг... Хэл нь халтирахгүй байна! “Хөдөө сая сая хүн аж төрж байна”! Яаж аж төрж байдгийг чи харсан уу? Чи урьд залуу байхдаа “Надад тийм газрыг нэрлээч” гэж дуулдаг байснаа санаж байна уу?.. “Орос тариачин гаслаагүй газрыг” гээд... санаж байна уу? Үнэн санаанаасаа сайхан дуулдаг байсан, тариачин хүнийг өрөвддөг өрлөг сэтгэлтэй байж. Чи одоо яагаад тэднийг өрөвдөхгүй байна вэ? Чи тэгэхэд хэний тухай дуулж байсан юм бэ? “Ард түмний тусын тулд, ард түмний төлөө” гэнэ... Тэгвэл Саша ард биш юм уу? Сэтгэлдээ ямар ч өө сэв, хир буртаггүй, ямар итгэл дүүрэн явлаа, гэтэл тийм хүнийг Сибирьт цөлчихөж байгаа юм, буудаж алж болохгүй юм бол үгүйдээ Сибирьт цөлөх гэж л дээ. Та нарын дуунаас чинь юу үлдэж вэ?.. Өөрсдийнхөө тэр Сталинд л мөргөцгөөж байна... гэв.

Марк Александрович босож сандлаа түлхэв.

—За, хүндэт эгч минь...

—Шуугих хэрэггүй, биеэ барь хэмээн эгч нь өгүүлээд,

—Марк, чи надад мөнгө өгье гэсэн, мөнгөөр нүглийн нүдийг хааж болохгүй. Гэм буруугүй, өмгөөл ивээлгүй амьтад руу мэс далайсан, тэгэхлээр өөрсдөө тэр мэснээсээ амь алдацгаана даа! хэмээснээ буурал тэргүүнээ гудайлгаж дүү рүүгээ хялайн харж хуруугаа гозойлгоод,

—Марк, чи тэгээд ээлж чинь ирэхийн цагт Сашаг нэхэн санаж, эргэцүүлэн бодно, гэхдээ нэгэнт оройтсон байх вий. Чи гэмгүй хүнийг өмгөөлөөгүй. Чамайг бас хамгаалах хүн гарахгүй дээ. Миний чамд хэлэх юм энэ байна гэжээ.

Нөгөө хэдэн хүн тайгын гүн рүү лавшран дөрөв дэх өдрөө явцгааж байв. Урд нь морин тэрэг, ард нь ангийн винтов буу үүрч морь унасан хөдөөгийн гүйцэтгэгч гэгддэг нойрмог хархүү явж байна.

Хөдөөгийн гүйцэтгэгч гэдэг нь тариачдын өртөөчлөн хийдэг хуягийн алба, нэг тосгонд хүрээд л хуяг солигдоно. Сибирийн тариачдын хүлээсэн элдэв албан журмын дотор ийм үүрэг бас байсан юм. Сайхь хархүүгийн эцэг, өвөө, элэнц нь бас л ингээд цөллөгийнхийг дагаж явсан, харин хуланцыг нь бол өөрийг нь ийнхүү тууж явсан болой.

Хүмүүсээ элдэв бүртгэл, гарын үсэггүй хүлээлгэн өгөж, хүлээж авдаг учраас ийнхүү хуяглан дагах нь ёс өдий зүйл ажээ. Жинхэнэ манаач нь бол тайга. Тайгад харийн хүнийг гучин мод газраас мэддэг учраас нуугдаж хоргодохын арга байхгүй. Хүнийг толгой түрийгүй шалгаж байгаа ийм цагт нууцаар аж төрөх боломжгүйг харуул хамгаалалт илтгэнэ.

Цөллөгийнхөн гагцхүү оноосон суурин газраасаа хаа нэгтээ оргоно. Эрх чөлөөг санаад бэтгэрч гүйцсэн цөллөгийн хүн өөрийг нь чухам юу хүлээж байгааг бодохгүй зүгээр л оргож босоод явчихна. Тэгэхдээ аль ч газар адилхан байдаг хаврын улирал ханхлахад төрөлх нутгаа санагалзан сэтгэл зүрх байж ядан шимшрэх урин цагийн эхэнд нэг оргоно, эсвэл Сибирийн түнэр харанхуй өвлийн олон сарыг яаж давна гэхээс сэтгэлд тэсэхүйеэ бэрх болдог намар эрт цагаар нэг оргоно. Гэтэл хугацаа дуусахаас ганцхан сарын өмнө өвөл цагаар оргочих нь бас бий. Хамаг санаа сэтгэл нь гэртээ харьчихсан, хүлээж ядаж байхдаа бичгээ авах гээд очтол бичгийнх нь оронд хугацаа сунгасныг мэдэгдэх вий хэмээн тэр нэгэн мөчөөс амиа гартал айхдаа оргож байгаа нь тэр. Өвөл зугтсан тийм оргодлыг хавар хайлсан цасан дороос олдог бөгөөд чухам тэр учраас түүнийг “яргуй” гэдэг билээ.

Харин зам зуураас оргоно гэж байхгүй. Тун сая шоронгоос тавигдсан, хорихоос салсан, бүгчим вагоноос гарсан болохоор замд явахад дур зоргоороо эрх чөлөөтэй алхалж яваа мэт санагдана. Бас муусайн юм тэргэн дээр байгаа болохоор түүнийгээ нууцгай авахын арга байхгүй. Түүнээс гадна цуг яваа улстайгаа дундаа нэг бичиг баримттай, оргочих юм бол бусад нь нэгссэн нэр олж, тэднийгээ хөөдөөд шинэ хэрэгт хийчихнэ. Оргох санаатай юм бол оноосон газраасаа л орго, хүн шиг байх хэрэгтэй шүү дээ.

Хонхор хотгороор үлдсэн цасны сүүлч хайлж, дээрээс нарны туяа нэвглэн гиймэр янзтай ч зам зөргөөр жиндүү нойтон, бүрхэг бүүдгэр байлаа. Унуул дархи, хөглөрсөн гишүү мөчир, сахлаг хөвд бүрхэж хөсрийтөн хуурайшсан мод, ялзарсан гуалин элбэг ч бут сөөг, цэцэг навчны аль нь ч байхгүй, гагцхүү ноднин жилийн борог өвс энд тэнд шаргалтан, ойн галзуу түймэр байсан мэт хаа сайгүй хуйхлагдсан мөр ором харлана. Нэгэн янзын урамгүй нэвсгэр ой зах хязгааргүй үргэлжилнэ. Хар мод л сэрийн сааралтах бөгөөд хаа нэгтээ нарс, хуш, гачуур үзэгдэж, хус, улиас бол бүр ч ховор тааралдана. Өндөр моддын оройгоор амьдрал байна уу гэлтэй тэнд зөөлөн салхи шуугиж, хөх цөцгий шулганан, хэрэм модноос модонд дүүлж, боргоцой шүжигнүүлэх сонсогдоно. Замын үзүүрт нөгөө л битүү ой, уул нуруу, салаа сархиаг үргэлжилнэ.

Канскийн орчимд ойр ойрхон тосгонтой байсан учир нэгэнд нь хүрч ирэхэд тэднийг хонуулахгүй гэхээс бушуухан дараачийнх руугаа явуулах гэж улайцгаана. Тэгээд хоноглох газар шөнө орой ирж, өглөө эртлэн цааш хөдөлнө. Айлын эзэн үүдний түгжээг түжигнүүлэн хараал зүхэл тавьж, сэрээчихсэн хүүхэд уйлаан майлаан болж, гэрийн эзэгтэй шалан дээр муусайн даавуу шуувуу хаялан амандаа үглэх агаад аягүй бол яаж л унтах сан дураараа болцгоо гээд хучлага дэвсгэр гэж юу ч хаяж өгөхгүй байх нь ч бий. Шалан дээр унтахад хүйтэн болохоор бие муу яваа Карцев хөхүүлэн ханиаж, Ивашкин авгай хүүхдээ санагалзан гунигтайяа санааширна.

Гэтэл тайгад тосгон цөөрч өртөөчлөх зам яг өдөртөө таардаг болов. Тайгын анхны гацаанд тэнд цагаан гэгээ тасраагүй байхад ирж сая нэг нойроо ханатал авцгаажээ.

Канскаас зайдуу гармагц хуяг нар Володягийн хүлээсийг тайлж,

–Одоо хоёр хөлөөрөө яв хэмээжээ.

Тэрээр биеийнхээ хөшөөг гаргаж жаал хөдлөөд эцэх цуцахыг мэдэхгүй хөнгөн шингэн алхлав. Харц нь нөгөө л хорсож занасан янзаараа. Хориход байсан хүний барил мөн дөө. Бүр яль шальхан юм хүртэл амь насанд хүрч мэдэх учраас байнга мэдээтэй байж, яах ийхээ хормын зуур шийдэж, хэнээс ч айхгүй, юугаар ч бууж өгөхгүй, харин ч өөрөө бусдыг айлгахыг эрмэлзэнэ. Борис, Саша, Ивашкин гурвыг “Сталины дэглэмийн санамсаргүй хохирогчид” хэмээн нигүүлсэнгүй ханддаг хэрнээ Карцевыг “бууж өгөгч” хэмээн ад үзэж, түүнтэй ярих битгий хэл хүн байна гэж тоож анзаарахгүй. Хамт явж, хамт унтаж, зовлонгоо цуг хуваалцаж яваа хүнээ ингэж үл тоомсорлож чадаж байгааг Саша гайхаж цөхнө.

Володя Квачазе түрүүнд нь явна. Бие муу Карцев амьсгаадан байн байн зогсож араас нь сажилна. Түүнийг зогсоход бүгдээрээ зогсоцгооно. Володя ингэж саатаж байгаад харамсан эргэж ч харахгүй зогсоно. Тэрээр Карцевын бие бялдар сул дорой байгааг сэтгэлийн тамир байхгүйгээс ийм байгаа, бууж өгснийх нь шалтгаан ч бас энэ гэж үзнэ. Тэгээд Карцевтай зэрэгцэн явж, хэцүү газар түүнд дэм тус болж яваа хүнийг дайсны талын туршуул үзсэн мэт сэжигтэй харна.

Володягийн эр зориг, дарга нарыг эсэргүүцэж байгаа байдал, нэр төрөө алдахгүй байгаа энэ тэр нь Сашад сайхан санагдана. Гэхдээ Володя хүний бодол санааг ерөөсөө ойлгож тусгаж авч чаддаггүй нэгэн дутагдалтай, Саша ч гэсэн ийм зантайгаа өөрөө ч мэддэг билээ. Тэрээр бүр эхний өдрөө л,

–Володя, учраа ололцохгүй юм гарах вий. Би бол намын чиг бодлогыг хуваалцдаг хүн. Өөрсдийнхөө үзэл бодлыг дор бүрдээ хадгалцгааж байя. Ашиггүй маргаан огт хэрэг байхгүй гэж хэлжээ.

–Сталины дуу хоолой бологчидтой маргаж байх хүсэл надад байхгүй нь бүр ч мэдээжийн хэрэг, гэхдээ та нар намайг ийш нь нэгэнт хөөж авчирсан бол миний амыг таглана гэж заяа нь байхгүй гэж Володя ихэмсэг хариулжээ.

Саша инээмсэглэв.

–Би таныг ийш нь хөөж авчраагүй, өөрөө хөөгдөж ирчихээд байна.

–Муу нь муудаа гэж тэр. Тэгээгүй бол та ч нөгөө Канскийнхнаас дутахгүй эрүүдэж байх байсан байлгүй.

–Та нар засгийн эрхэнд байсан бол биднийг яах байсныг төсөөлж байна гэж Саша хэлэв.

–Та бол бидний үед ч гараа өргөөд байх хүн гэж Квачазе занав.

–Залуус минь, маргалдахын хэрэггүй хэмээн Борис завсраас ярианд орж, –Маргалдана гэдэг улс төрийн хэрэгтнүүдийн заяаны ганц лай юм... Гэтэл эрүүгийн хэрэгтнүүд бат нэгдэлтэй, шоронгийн захиргаа тэднийг ер хөнддөггүй байна гэв.

–Эрүүгийнхэн бол хүний сүг! Хар амиа хичээсэн яргачид. Таваг угаадсаар нөхрөө худалдчихна. Тэд нар чинь шоронгийн захиргааны гол тулгуур, туслагч нь байдаг юм. Эхнэрээ алчихаад найман жил авлаа гэхэд цаадуул нь үлгэр жишээ байсан гээд тэн хагасыг нь хасаад хаячихна. Гэтэл үйлдвэрээс гутлын хоёр зан аваад гарсан бол арван жилтэй гэж Володя өгүүлжээ

Тайга улам бүр аглагшлаа. Нөгөө л битүү өтгөн ой хөвч бүрхсэн уулс нурууд, ухаа толгод, ангал жалганууд, нөгөө л моддын оройгоорх шувуудын жиргээн, нөгөө л нойтон бүрхэг зөрөг. Хусан төгөл дотор нэг өндөр янхир манж нэгэнтээ зурсхийн үзэгдэж, модны мөчир тачигнуулан далд оров.

Өглөөнөөс нартай өдөр болов. Хэдийгээр нарны туяа зөрөг дээр бараг хүрч тусахгүй байгаа боловч явахад эрхиш хөнгөн сэргэг байлаа.

Тас хар болтол нь утаа идсэн туургатай, тааз, цонх, зуух аль нь ч байхгүй, түлэгдэж дагтаршсан газар шалтай өчүүхэн умгар ойн байшингийн ойролцоо өдөр дунд үдлэн зогсоцгоов. Тэр байшинд өвөл шалан дээр нь гал түлж, утаа нь дээврийн нэг нүхээр гадагшилдаг ажээ. Нэг буланд нь тэвэр хэртэй хуурай мөчир хэвтэнэ. Хожим ирэх хүн цас шуурга, жавар салхинаар ирж болох тул хуурай мод олж гал түлж чадалгүй хатуу шалан дээр хөлдчихөж мэдэх учраас түрүүчийн хүн явахдаа ийнхүү түлш үлдээдэг билээ. Сайн хүн бол гишүү мөчир үлдээгээд зогсохгүй чийг авахгүй газар хайрцаг шүдэнз нуучихна.

Тэд задгай гал түлж бяцхан булгаас ус авчраад шар будаа агшааж цай чаналаа.

Шар будааг өчигдөр Борис гацааны хоршооноос олж авчээ. Худалдагч нь танил хүн байсан учир мухлагаа шөнө онгойлгож, шар будаанаас гадна хайрцаг тамхи барьж, ганц шил нэрмэл архи олж өгснийг тэд тэр оройд нь уусан аж.

Борис энэ тайгын бөглүү гацаанд хүртэл хүмүүс өөрийг нь мэдэж байгаа, бас өөрийг нь байхгүй бол цаадуул нь баларна гэж бодохоос идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хэвийнхээ байдалд эргэн орж, тэрээр Богучаныд ямар ч атугай адгийн хүн биш байх болно гэсэн итгэл сэргэн байв.

Цаадуул нь мөнгө байхгүй, Саша мөнгөтэй ч гэсэн мөд ажилд орж чадах эсэх нь бүү мэд учраас айлд хоносны хөлс, оройн хоолны мөнгийг Борис л бусдынхаа өмнөөс төлнө. Өөрөө Богучаныд ажил олох нь лавтай. Тэрээр эргэмэл захтай цэрэг цамцтай, борооны цувтай, өнгө дагасан саравчтай малгайтай, яс сайтай савхин гуталдаа өмднийхөө түрийг чихэж өмссөн байх нь даргатай төстэй харагдана. Бас боловсролтой дарга нар шиг намуухан хэрнээ эрсхэн дуу хоолойтой. Тийм даргатай маргах хэцүү, тэртэй тэргүй түүнд дийлдэх учраас шаардаж байгаа юмыг нь бушуухан биелүүлсэн нь дээр байдаг болой.

Мань хүн одоо ч гэсэн бусдыгаа удирдаж нэгийг нь усанд, нөгөөг нь мөчирт явуулав. Ой дотроос хуурай мөчир олдохоор болчихсон цаг учир өвөлжөөнд байгаа гишүүнд гар хүрэхгүй гэж шийдэцгээжээ. Ганцхан Карцевыг юманд явуулсангүй. Карцев нүдээ анин шаналсан өлөн цагаан нүүрээ наранд ээгээд хожуул дээр сууж байна.

Нөгөө худалдагч тэдний харгалзагчаар ээлж нь болоогүй нэгэн гарын дүйтэй тусч сайн хүүг зориуд явуулахаар зохицуулсан юмсанж. Тэрээр үдэлж байх зуур үйсээр хүн бүрд халбага хийж өгөв. Цайвар хонгор үстэй хөнгөн шингэн хүү. Мориндоо мордолгүй, морио хөтлөөд явган алхжээ. Саша тосгоноос гарахдаа л түүнтэй цуг хөдөлсөн, тэр чигээрээ ханиндаа алхсаар яваад энэ үдлэх газар иржээ. Замдаа Сашад бугаа өгч цорхируу буудуулсан боловч цаадах нь оносонгүй.

–Баавгай тааралдаад онохгүй бол ч барагтайхан хэрэг болох вий гээд хүү инээд алджээ.

–Чи өөрөө баавгайн анд явж байсан юм уу?

–Явж байсан, гурван ч удаа. Баавгайг бид ичээнээс нь намнадаг юм. Араатан хаана ичсэнийг ноход шиншлээд мэдмэгц бид сургааг огтолж бэлтгээд ичээнийх нь тархи руу шаачихна. Тэгэхлээр нөгөө амьтан чинь өөрөө зүтгэлж гарч ирнэ, бид ч буудчихна. Ац модтой юм уу, аягүй бол хутгатай манай энд чинжаал гэдэг юм. Чинжаалтай явдаг ч хүн бий. Баавгай чинь зальтай араатан, хүн рүү бол харайж дайрдаг, адуу юм уу үхэр рүү бол гэтдэг амьтан байгаа юм.

Арслан, бар, заан энэ тэр гээд баавгайнаас хавьгүй хүчтэй араатан бий гэж Сашаг хэлэхэд хүү жумалзан инээмсэглэжээ... Үнэмшихгүй байгаа нь тэр.

Дэргэдүүр нь өнгөрч яваа ойн цоорхой дээр жилийн өмнө эрүүгийн хэргээр цөлөгдсөн гурван хүнийг яаж алсан тухай мөнхүү инээмсэглэн байж ярив.

–Тэднийг яг ингээд л тууж явж л дээ, гэтэл мань эрсүүд нэг тосгонд хөзөр тоглосон гэнэ. Манайхны багачуул тэдэнд мөнгө байсныг үзсэн юм байж. Тэгээд энд тосож ирээд буудаж гарчээ. Цаадуул нь зугтсан боловч овоо хараанаас мултарч чадалгүй, үхэтхийн унацгааж цасанд дарагджээ. Жавар гэдэг жигтэйхэн.

Араатан амьтан энд элбэг болохоор тэдний хүүрийг юу ч үгүй идчихнэ гэж манайхан боджээ. Гэтэл яг тэр үеэр бэлтгэлийн бүрэн эрхт төлөөлөгч районы төвөөс үүгээр явж таарч, ноход нь үхсэн хүмүүсийн үнэрийг авчихжээ. Мөрдөж мөшгиж манайхныг олоод тэднийг Новосибирск рүү явуулсан юм. Гэтэл танхай амьтад тэднийг шоронд нь алчихсан гэнэ билээ.

–Тэд тэгээд алсан улсаасаа их мөнгө аваа юу?

–Дөнгөж аравхан рубль авсан гэнэ билээ.

Задгай галын дэргэд ярилцаж байтал энэ явдлын тухай дахиад яриа үүсэв. Энэ тухай Борис Канскт цөллөгийнхнөөс дуулсан учир мэддэг, Квачазе хориход байхдаа дуулсан учир бас мэддэг юм байж. Хоёр залууг аваачихаас өмнө тэр явдлын тухай шоронгийнхон дуулчихсан байсан учир шоронд аваачсаных нь шөнө хоёуланг нь алчихжээ. Хоорондоо эвтэй олон хүнтэй том өрөөнд байсан учир хэн нь тэр хоёрт гар хүрснийг яагаад ч улайгаж чадаагүй гэдэг.

–Тэгж цааш нь харуулсан нь сайн хэрэг болжээ гэж Володя өгүүлээд, –Тэгээгүй бол их л сайндаа таван жил өгөөд муусайн цөллөгийнхнийг алсан юм, ер яах вэ дээ гээд ганцхан жилийн дараа суллаад тавьчих байсан юм. Одоо бол хоригдлууд сангийн утсан холбооноос илүү урт чихтэй гэдгийг орон нутгийн хүмүүс мэдэж авсан байгаа. Улс биднийг хамгаалахгүй юм чинь өөрсдөө л өөрснийгөө хамгаалах болж байна. Өөр зам алга гэв.

–Володя, эрүүгийн хэрэгтнүүд хүн биш гэж та өөрөө ярьж байсан шүү дээ! Тэднээр хэрэг шүүлгэж яаж болох вэ дээ? гэж Саша асуув.

–Сэхээтний хоосон үг. Тамын ажилтай хорих газар өөрийн хуультай байдаг юм, тэр хударганд ороод үзвэл аяндаа ойлгоно оо гэж Володя дүрэмдлээ.

–Сэхээтнүүд рүү дайрахын хэрэг юу билээ? Бага ч гэсэн эрхбиш хэрэгтэй улсууд шүү гэж Саша хэлэв.

Володя хуруугаа гозойлгож,

–Зарим нэг нь тийм шүү гэв.

–Та ч гэсэн өөрөө сэхээтэн биз дээ.

–Та яагаад намайг сэхээтэн гэдгээрээ бахархдаг гэж бодож байна?

–Гал нээсэн хүн анхны сэхээтэн байсан юм. Тэр үеийнх нь хүмүүс түүнийг мэдээж алсан. Нэг нь хуруугаа түлсэндээ, нөгөө нь тавхайгаа хайрсандаа болж алж байсан бол гурав дахь этгээд зүгээр л битгий цоролзоод бай! гээд л алж байсан. Битгий цоролзоод бай! гэдэг чинь бүр чулуун зэвсгийн үед ч байсан хэрэг гэж Саша өгүүлэв.

–Нарийн ухаан сийлсний нэгдүгээр шагналыг Сашад өгье хэмээн Борис дуу өгч,

–Сашад нэгдүгээр шагнал өгөхийг Володя, та зөвшөөрөх уу? гэв.

–Өгөх юм нь байгаа юм бол өг л дөө гэж Квачазе өчив.

Дор бүрдээ номхон томоотой байх эрмэлзэл дүүрэн байцгаалаа. Нар моддын орой дээгүүр шингэх тийш хандаж байвч тэр хэд дулаан илчийг нь амьсгалан пальто, малгайгаа тэргэн

дээрээ хаячихаад хөнгөхөн хувцастай алхацгаана. Дагаж яваа хөвгүүн хүнд тус болохын түүс болсон амьтан, буугаараа хүртэл буудуулж, ямар юмных нь хуяг байх вэ дээ, ерөөсөө энэ байдлыг цөллөгт туугдаж яваа гэхийн арга алга. Тэд нар анх удаагаа айлын ширээний ард биш ойд, задгай түүдгийн дэргэд хооллоцгоолоо. Нарсны мөчир чад чад ноцож, давирхай, түлэнхий будаа энэ тэр ханхлан, цайн дотор нарсны шилмүүс хөвөөд үнэхээр хүүхэд ахуй цагийн дурсамжийг санагдуулна. Пионерийн зусланд түүдгийн хажууд сууцгааж байсан цаг чухамдаа тун саяхан билээ.

Карцев нарны манант туяанд өвчтэй нүүрээ ээн сууна. Ивашкин ухаантай ярианд дуртай болохоор Володя, Саша хоёр руу ээлжлэн толгой дохино. Тэрээр өөрийнхөө мэргэжлийг сэхээтнийх, басхүү онцгой мэргэжил гэж үзнэ. Яарснаас болж л үсгийн алдаа гарчихаад, өөрөө огт оролцоогүй мөртлөө ингээд Сибирээр туугдаж явна. Нөхөр Сталины хэлсэн үгэнд “нээх” гэж байсныг “нуух” гэж алдаатай өрцгөөсөн ажээ. Тэгээд зургаан хүн яланд оржээ. Ивашкины гэрт авгай нь гурван охинтойгоо үлдсэн байна.

Хуяг хөвгүүн тэдний яриаг бас чагнан инээмсэглэнэ. Хоолноос нь хороохгүй хэмээн агшаасан будаанаас амсах төдий гоочлов.

Тэрэгчин муухай царайлан агшаасан будаа, цай хоёрын аль алинаас нь татгалзаж, тэргэн дээрээ юмхан зажилсан болоод морио амсхийж ногоо хэд хазтал өөрөө зүүрмэглэв. Дараа нь морио хөллөлөө. Галын дэргэд нозоорсон хүмүүс дуртай дургүй босоцгоов. Тэгээд хөдөлцгөөх нь тэр. Таван километр хэртэй явгал модны оройгоор гэнэтхэн салхи исгэрэн шуугиж харуй бүрий нөмрөн цасан шуурга тавилаа.

Чуна голд гэгээ тасраагүй байхад хүрэх санаатай тэрэгчин ч яарч, хуяг хөвгүүн ч шамдлаа. Цас бут сөөг дээгүүр цасан малгай нэвсийлгээд тэртэй тэргүй хариугүй муу замыг бүр хэнийг нь алдуулж хаячихаад яг эхэлсэн шигээ санамсаргүй түргэн арилав. Тэрэгнийхээ араас түлхэж хүч өгцгөөн түрүүчийнх шигээ түргэн явцгаалаа.

Гагцхүү Карцев тэгж явж чадахгүй амьсгаадан бахардаж, байн байн мод түшин зогсож бүгшин ханиалгана.

–Карцев, тэргэн дээр суу гэж Саша хэлэв.

Гэтэл тэрэгчин дургүйцэж,

–Би хүн зөөх гэж хөлслүүлээгүй, морь ч хүчрэхгүй, зам ч гэж най алга гэв.

–Чи ч хүний ханшгүй эр юм аа гэж Ивашкин хэллээ.

Саша морины жолооноос шүүрч авлаа.

–Зогс! Карцев, суу!

–Чи болиорой, бүү гар хүр! хэмээн тэрэгчин хашгирч, –Буцаад явчихна шүү, танхайрвал яадгийг та нарт цаадуул чинь үзүүлнэ ээ, гайгүй! гэв.

–Аав гуай минь, бид хэрүүл уруулаар яах вэ гэж Карцевыг тэргэн дээр суулгах зуур Борис даргамсуу өгүүлэв.

Тэргэн дээрээс аль хөнгөнөөс нь шилж хоёр чемодан авахаас өөр үггүй болсон тул хуяг түүнийг мориндоо тохлоо. Ганцхан Володя Квачазе л ганц ч үг дуугарсангүй, энэ бүхэн яаж дуусахыг хэнэггүй хүлээж байв. Тэрээр нөгөө “бууж өгөгчийг” үхэх гэж байсан ч заяа нь өмөөрөхгүй ажээ.

Чуна голыг жижиг онгоцоор гаталцгаав. Тэр онгоц цаад эрэгт нь хүрдэггүй учир голын үлдсэн хэсгийг тэргээ чирцгээж, юмаа барьцгааж явган туулцгаалаа. Тэгээд усан гүзээ болтлоо норцгоожээ.

Хэмжээгээр том боловч байшингууд нь нэвсийн харлан малынх нь хашаа хороо эзгүйрч эвдрээд доройтож үгүйрсэн тосгон таарчээ. Байшингуудаас эртэдсэн галын гэгээ гэрэлтэж, найрлацгааж байгаа нь илт согтуу хөлчүү хүний хашгирах, дуу дуулах сонсогдон, тал нутгийн хүрэн халиун үстэй, өсгөлөн биетэй сибирьчүүдтэй огт төс байхгүй өнгө өнгийн үстэй, өндөр нам чацтай ойчин, тайгачин элдэв харчуул гудамжаар гуйвлан өнгөрцгөөв. Хураалттай гуалин дээр инээлдэн суусан охид хөвгүүд хуягийг дуудаж өнөөдөр манай сүмийн баяр гэж хэлэв. Хуяг тэр даруй бачимдаж, тууж ирсэн хэдийгээ бушуухан тушаахын тулд даргыг хайхаар гүйж одов.

Даргыг хүлээж байх зуур энд цөлөгдсөн хоёр хүн ирэв. Нэг нь өтгөн хөвсгөр халимагтай, аажуу хөдөлгөөнтэй, Сашад бол Зөвлөлүүдийн тавдугаар байшинд олныг үзэж нүд дассан улс төрийн зүтгэлтний дүрийг санагдуулах данагар байрын эр, нөгөө нь зовсон хатаамал царайтай, шар үстэй туранхай хүүхэн. Нөгөөдүүл зам боогдсоноос хойш ирж байгаа түрүүчийн бүлэг учраас тэр хоёр тэдний дотор өөрийнхнөөсөө байгаа эсэхийг мэдэх гэж яарч ирсэн нь тэр ажээ.

–Сайн байцгаана уу, нөхдүүд ээ!

Эмэгтэйн харц Квачазе дээр тусаж, түүний хариу харцнаас үзэл нэгтнээ олж харах шиг болжээ. Володя овгоо хэлсэнд тэр хоёр түүнийг мэддэг, мань хүн ч нөгөө хоёрын овгийг мэддэг болж таарав. Тэд тэврэлдэн үнсэлдсэн боловч нөгөө хоёр бусадтай нь танилцсангүй. Эрэгтэй нь нөхөрсөг янзтай инээмсэглэсэн атлаа хэнд ч гараа өгсөнгүй, болохгүй хүнтэй гар барих буюу гараа өгөхгүй хүн рүү хий сарвайх вий гээ биз. Эмэгтэй нь инээмсэглэсэн ч үгүй.

Тэр хоёр Володяг аваад явлаа. Тэрээр хар хөвөнтэй цамцтай, ууттай юм үүрсэн, өндөр гулбилзсан эр тэдний асуултад хариулан дунд нь явж харагдана. Шуудан бүтэн хоёр сар ирээгүй болохоор асуух юм их байгаа бололтой.

–Далдар! хэмээн доромжлуулсан Борис тэдний араас өгүүлэв. Володя улс төрийн эвийн журмаас илүү эрхэм журмыг зөрчжээ.

Явуут юм зажилсан, занхгар нүүртэй, согтуу уймраа нэг эр нүд нь орой дээрээ гарчихсан гүйж ирэв.

–Цөллөгийнхөн аль нь вэ? Эд нар уу? Та нар яасан хар толгойтой улс вэ, орос хүн та нарыг хийгээ гэж үү? Ай-яа-яа!

Мань хүн тэднийг тосгоны захын пийшин нь нурчихсан нэг хаямал байшинд авчрав. Гэтэл тэд нар хувцас хунараа хатааж, өөрснөө дулаацаж, бие муу яваа Карцевыг дулаан газар хэвгүүлмээр байдаг. Тэгээд аль хэзээний хаягдсан энэ оромжийг харж танилцаж байтал нөгөө занхгар толгойт хэдийн бараа сураггүй алга болчихсон байв. Тэрэгчин бас юмыг нь газар авч хаячихаад яваад өглөө.

Орон нутгийн захиргааг шахъя, алив Ивашкин явъя! гэж Борис хэлэв.

–Хаашаа явах билээ? Тосгон тэр аяараа найрлаж байна.

–Ярихыг нь би ярина, та идэх юм нааш авчрахад л туслаарай гэж Борис түүнийг тайвшруулав.

Тэр хоёр яваад өгөв. Саша чемоданаасаа цэвэрхэн хос дотуур хувцас, ноосон оймс, цамц гаргаж Карцевт сарвайв.

–Хувцсаа соль.

Түүний туранхайг үзээд Саша гайхаж хоцров. Хавирганых нь яс хэрзийж, өвдөг нь гүрдийн, яс арьс болсон урт хөл нь чүүрийж, хоёр гар нь өөрийн эрхгүй унжиж, дал нь шувууны тас цавчсан далавч шиг ёрдойх ажээ.

–Өлсгөлөн зарлаад та ч их туржээ гэж Саша өгүүлэв.

–Гуурс шургуулж байгаад хүчээр хооллох гэдэг байсан юм гээд Карцев цамцныхаа хормойг дотуур өмдөндөө дүй муутай хийх зуур,

–Дараа нь эмнэлгийн хоолонд оруулж сүү уулгадаг байсан. Би бүдүүн судсаа огтолж цус алдаж үзсэн гэв.

Тэрээр нүүр нь улаанаар толборон, нүд нь хачин цахилан байх нь халуурч байгаа бололтой, гэтэл тэдэнд халууны шил байх биш дээ, байлаа ч гэсэн маргааш тэртэй тэргүй замдаа гарах юм чинь халуун хэмжихийн ч хэрэг алга. Тэгсээр сая нэг хувцаслаж гүйцээд Сашагийн цэмбэн хөнжлийг ороон нөмөрч вандан дээр сууж хана налаад нүдээ анилаа.

–Та юунаас болж судсаа огтолсон юм бэ? гэж Саша асуув.

Карцев хариу дуугарсангүй, сонсоогүй юм уу эсвэл зүүрмэглэсэн байх.

Саша пийшинг шалгаж үзэв. Пийшингийн дээд доод хоёр амнаас төмөр утас ёрдойж, хаалгыг нь ямар нэг этгээд хэдийн суга татчихжээ. Саша галлах юм уу гэснээ Борис өөр байр олж магадгүй гэж бодоод болив.

Борис, Ивашкин хоёр нэг талх, бас үйсэн хувинтай цөцгий авчрав. Өөр юу ч олсонгүй. Хамаг амьтан согтуу, ярих хүн байхгүй, хонуулахаар гэртээ хэн ч оруулаагүй учраас тэр хоёр өөр

байр олж чадсангүй.

Ивашкин гаднаас нэг модны хугархай олж ирж нарийхан жиргэж байгаад галлах гэсэн боловч ерөөсөө унтарчихаад болдоггүй, шүдэнзний гарз л боллоо.

Харанхуйд цөцгийгөө талхтай идэцгээв.

–Хүйтэн хоол оргүйгээс дээр юм гэж Борис айлтав.

Карцев юм идэхгүй, харин юм уумаар байна гэв.

Гэтэл ус байсангүй.

–Би Володягийн найзынд очъё, Карцевыг ганц шөнө аваад хоног л доо гэж Саша хэлэв.

Борис эргэлзэн толгой сэгсрэв.

–Авахгүй дээ. Гэхдээ үзээд алдахад яахав. Би түүнтэй хамт явъя.

–Яах нь вэ?

–Тосгон тэр чигээрээ согтуу байна, нөгөө гуалин дээр сууж байсан залуус тун зэвүүн царайтай байна билээ.

Үүлгүй тэнгэрт арван тавны сар мэлтийгээд дотроос гадаа илүү гэгээтэй байв. Гуалин дээр нөгөө охид хөвгүүд суусаар л аж. Хөвгүүдийн нэг эндхийн хэлэмгий доломгой эр бололтой гараа савчин ямар нэг инээдтэй юм ярьж, нөгөөдүүл нь нирхийлцэн инээлдэж байв. Тэрээр Саша, Борис хоёрыг үзээд,

–Хөөе, мартагдсан хаягдсан хүн гуай, нааш ир гэж хашгирав.

–Битгий тоогоорой гэж Борис аяархан өгүүлэв.

–Яалаа гэж тэр вэ? хэмээн Саша гуалин руу зүглэж, –Юун хэрэг болоо вэ? гэж асуув.

–Яагаад гудамжаар холхиод байна? Хүүхэн хайцгаагаа юу? Ташуурын амт үзэхгүйсэн болов уу?

Нөгөө залуухан хуяг гуалин дээр мөн чимээгүй инээмсэглээд сууж харагдана. Гэхдээ тэр хоёрыг балбаад эхлэх юм гэхэд хуяг аанай л инээмсэглээд байж байна гэдэг нь илэрхий байв.

Саша Борис руу эргэж хараад,

–Нээрэн тийм байна. Энд ямар сайхан бүсгүйчүүлтэй газар вэ, хараач! гэв.

–Сайхан шүү, гэхдээ та нарт хүртээлгүй! гэж нөгөө залуу хашгирав.

–Ганцхан чамд уу? хэмээн Саша мушилзаж, –Чи барах юм биз дээ? гэв.

Гуалин дээр инээд алдацгаав.

–За за, чи хамаагүй, тэгж... гэж залуу эхэлтэл,

–Хамаа намаа хэмээн Саша дооглоод, –Чамай мууг... гээд нөгөө химийн үйлдвэр дээр цуг ажиллаж агсан ачигчдын хэн нь ч гэсэн атаархмаар муухай билэндэж хараав.

Тэгээд өнгөрөөд яваад өглөө.

–Залуус минь, ихэрхэхийн хэрэг байхгүй, томоотой байцгаах хэрэгтэй гэж Борис нухацтай хэлээд Сашагийн араас хөдлөв.

Замдаа мань хүн Сашад,

–Таныг энд цааш нь харуулчихгүй бол та их урт насална. Та юухан хээхэн үнэмшүүлж чадаж байна шүү гэв.

Байшингийн хаалга түгжээгүй байлаа. Володя нөгөө эрэгтэй эмэгтэй хоёртой ширээ тойрон суужээ. Керосин дэнлүү асаатай байна.

–Эд нар бол Панкратов, Соловейчик хоёр, би та нарт эдний тухай ярьж байсан гэж Володя өгүүлэв.

Эрэгтэй нь инээмсэглэхийг үзэхүл тэдний тухай зөв юм ярьсан бололтой.

–Сууцгаа нөхөд өө, бидэнтэй цай ууцгаа.

–Баярлалаа!

Саша суулгүй шууд Володя руу харж,

–Карцевыг яах вэ? гэв.

–Үгүй, би яах ёстой билээ?

–Чи энд хонох гэж байх шив дээ. Түүнд зайгаа тавьж өгвөл ямар байх вэ?

Володягийн өмнөөс нөгөө эрэгтэй хүн,

–Манайд хэн хонохыг би аль нэг хэмжээгээр шийднэ шүү гэж хариулав.

–Ганц шөнө хоночих айл та мэдэхгүй биз? гэж Борис асуув.

–Энд дайрч яваа улсыг хэн ч оруулдаггүй юм. Өвчтэй хүнийг тэгэх тусмаа оруулахгүй.

Эмэгтэй нь Володяд хандан,

–Та сүүлчийн удаа Ильинийг хэзээ харсан бэ? гэв. Саша гадагшаа гарсан хойноо,

–Намайг юухан хээхэн үнэмшүүлж чадаж байна гэж таны ярьсан чинь энэ дээ гэж харамсан өгүүлэв.

–Хонгор минь, эд чинь улс төрийнхөө тачаалд автагдчихсан байна, улс төрийн тачаал гэдэг чинь юунд ч дийлдэшгүй зүйл хэмээн Борис хариулав.

Энгельсийн өгүүллийн тухай захидлыг Поскрёбышев Улс төрийн Товчооны гишүүдээр уншуулаад ажлын өдөр дуусах дөхөж байхад Сталины ширээн дээр тавив.

Өгүүллийг нийтлэх шаардлагагүй гэдэг дээр цөм санал нийлжээ. “Большевик” сэтгүүлийн редакцийн зөвлөлд өөрчлөлт оруулах тухай захидлаар асуулга явуулан гаргаж байгаа шийдвэрийн тухайд мөн бүгд санал нэг байжээ.

Энэ хоёр шийдвэр хоёулаа бүтнэ гэдэгт Сталин эргэлзээгүй аж. Учир юун гэвэл Стецкийг хөдөлгөж байгаа нүүдэл бол зүйтэй. Стецкий бол Бухарины талын хүн, харин Бухарин өөрөө тэдний нөөцөнд байгаа. Ноднин Смирнов, Толмачёв, Эйсмонт гурвыг, уржнан Рютиныг өгөхгүй гэж байсны адил Бухариныг одоохондоо тэд нар өгөхгүй.

Гэхдээ өнгөрсөн, одоо, ирээдүйн бүх өрсөлдөгч нарыг ямар ч байлаа гэсэн устгасан байх ёстой, тэгсэн ч байх болно. Дэлхийн цорын ганц социалист улс дотооддоо хөдөлбөргүй тогтвортой байж гэмээж нь сая тэсэж чадна, тэр нь чухамдаа гадаад байдал дээрээ тогтвортой байхын баталгаа юм. Дайн боллоо гэхэд улс хүчирхэг байх ёстой, энх тайвныг хусэж байвал улс хүчирхэг байх ёстой, бусад нь түүнээс айдаг байх ёстой.

Тариачны орныг ахар богино хугацаанд аж үйлдвэрийн орон болгохын тулд эд материалын болон хүн ардын тоо томшгүй их хохирол хэрэгтэй. Ард түмэн ийм хохирол хүлээхэд бэлэн байх ёстой. Гэхдээ ганц урам зоригоор санасандаа хүрэхгүй. Ард түмнийг албадаж байгаад хохирол хүлээлгэх хэрэгтэй. Үүний тулд ард түмний айдас төрүүлсэн хатуу засаг хэрэгтэй. Айсан дээр нь байнга айлгаж байхын тулд аливаа аргыг ашиглах хэрэгтэй, үүний тулд бууршгүй ангийн тэмцлийн онол бүхий л бололцоог нээж өгч байна. Хэрэв энэ завсар хэдэн сая хүн алагдах юм гэхэд түүх нөхөр Сталиныг уучилна. Хэрэв мань хүн улсыг өмгөөл ивээлгүй орхиж, сөнөж унахаас өөр замгүй болгох юм бол түүх түүнийг хэзээ ч өршөөхгүй. Аугаа их зорилго бол аугаа их эрч хүчийг шаардана, хоцрогдсон ард түмний аугаа их эрч хүчийг гагцхүү аугаа их хатуу гараар хөдөлгөнө. Аугаа их захирагчид цөм харгис хэрцгий байсан. Одоо “Академия” хэвлэлийн газрын захирал байгаа Каменев Макиавеллийг хэвлэж гаргасан нь санаандгүй хэрэг биш. МАНЬ ХҮНИЙ төлөө л гаргасан, хэрэглэж байгаа аргыг нь аль арван тав, арван зургадугаар зууны үед мэдэгдэж байсан зүйл гэдгийг ӨӨРТ нь харуулах гэсэн санаа. Каменев эндүүрч байгаа нь тэр. Макиавеллийн зөвлөмжүүд хуучирсан. Яг тэгж ярих юм бол эдгээр зөвлөмж арван тавдугаар зуундаа тохирч байсан эсэх нь бүү мэд! Айхтар хурц ч гэсэн өнгөцхөн, диалектик авцаа байхгүй, бүдүүвч зүйлс. “Ард түмэн дарангуйлан захирагчаа хайрлан хүндэлдэг засаг бол ард түмнээсээ хамаарах учраас сулхан засаг, ард түмэн дарангуйлан захирагчаасаа айдаг засаг бол гагцхүү тэр дарангуйлан захирагчаас хамаарах учраас хүчтэй засаг”. Энэ томъёолол бол зөвхөн зарим нэг талаараа л зүйтэй юм. Гагцхүү ард түмний хайр хүндлэлд түшиглэсэн засаг сулхан засаг гэдэг бол үнэн. Гэхдээ гагцхүү дарангуйлан захирагчаас айж бишрэхэд түшиглэсэн засаг бол бас л тогтвор муутай засаг. Дарангуйлан захирагчаас айхын зэрэгцээ түүнийг хайрлан хүндлэхэд түшиглэсэн засаг л тогтвортой засаг. Айлган сүрдүүлж байгаад хайр хүндлэл хүлээж чадсан хүн л аугаа их захирагч мөн. Түүний засгийн аливаа харгис хэрцгий бүхнийг ард түмэн, түүх хоёр өөрийнх нь дансанд биш гардан гүйцэтгэгчдийн дансанд биччих тийм хайр хүндлэл

байх юм.

Троцкийг хилийн чанад руу цөлсөн явдал хүнлэг алхам байсан, тэгснээрээ алдаатай алхам болсон юм. Яагаад гэвэл Троцкий эрх чөлөөтэй үлдсэн учраас үйл ажиллагаа явуулсаар байна. Зиновьев, Каменев хоёрыг мань хүн одоо хилийн чанад руу явуулахгүй, ард түмэн, улс орныг хамгаалахын тулд зайлшгүй босгох шаардлагатай айлган сүрдүүлэх цайзын анхны чулуу нь тэр хоёр болно. Дараа нь холбоо сүлбээтнүүд нь тэр хоёрын замаар орно. Бухарин бол тэдний хамсаатан, Каменевынх руу арын хаалгаар нь орж гарч, түүнтэй нууц хэлэлцээ явуулан, Улс төрийн Товчоонд Сталины оронд Зиновьев, Каменев хоёрыг байлгасан нь дээр гэж ярьсан. Холбоотноо өөрөө олсон хойно тэднийхээ замаар л орох болно доо.

Улс төрийн бодлогод өршөөх өрөвдөх зай байж болохгүй. Мань хүн хэрвээ хэн нэгэн хүнийг өрөвдөж байгаа бол гагцхүү Каменевыг л өрөвдөж байгаа. Гэхдээ Каменев өөртэй нь нэгсэхийн оронд Зиновьевтэй нэгсэж байна гэдэг үүднээс л өрөвдөж байгаа. Уул нь халирхай, хүний үгээр “санаа амар” хүн, нэмэрт нь Тифлисийнх гэж байгаа. Тифлист гимнази төгссөн, тэнд олон жил аж төрсөн хүн. Эелдэг, ялдам, ёсорхуу бас тэгээд яльгүй ихэмсэг, гэхдээ цайлган ихэмсэг энэ тэрийг нь бодоход еврей, гүрж зангаас аль аль нь жаахан бий. Тэрээр боловсролтой, улс төрийн байдлыг сайн баримжаалдаг, дүгнэлт сэлтийг яг оновчтой тодорхой томъёолж чаддаг, Ленин ч тэрийг нь зүй ёсоор үнэлдэг байсан юм. Нэр алдар хөөцөлддөггүй, удирдлагад гарах гэж өрсөлддөггүй, заяаны хоёрдугаар хүн. Лениний үед тийм байсан, нөхөр Сталины үед тийм байж болох л хүн. Тэгье гэсэнгүй! ӨӨРӨӨС нь чалчаа Гришкаг (Зиновьев) дээр гэж санаж! Нэг үе тэр хоёр бие биеэ сайн ойлгодог, сайхан хамсаж ажилладаг байсан. Чухамхүү Каменев л өөрийнх нь, нөхөр Сталины нэрийг намын Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалд дэвшүүлсэн. Гэхдээ зөвхөн Троцкийн эсрэг ашиглах гэж л түүний нэрийг дэвшүүлсэн, намын аппаратыг Троцкийн эсрэг лантуу болгоно гэдгийг Зиновьев тэр хоёр л хамтарч бодож олсон зүйл, хүний гараар могой барьж сурсан улс. Гэтэл тэд гол юмаа ойлгосонгүй. Намын аппарат бол лантуу биш намын аппарат гэдэг чинь засгийн хөшүүрэг. Өөрт нь энэ хөшүүргийг өгснөөрөө тэд нар засгийн бүх эрхийг түүнд гардуулсан хэрэг. ТҮҮНИЙ суу билэг нь ганцаараа үүнийг ухаарсан явдал юм. Тэгж яривал Ленин ч бас үүнийг ухаарсан, гэхдээ шууд биш жилийн хойно ойлгосон, дэндүү орой ойлгосон! Харин Каменев бол Ленин ТҮҮНИЙГ Ерөнхий нарийн бичгийн даргаас халахыг шаардаад байхад хүртэл нөгөө учрыг ухаарахгүй, Лениний захидлыг хэрэгсэхгүй байхыг их хуралд санал болгосон. Тэгээд Ленинийг нас барсны дараа Троцкий төдийгүй Каменев, Зиновьев хоёр ч гэсэн Лениний өвөөс тусгаарлагдахад хүрэхэд сая л учрыг ухаарсан. Чухам тэр үед л мань хүн улс төрийн зөв сонголт хийж, бүх намтайгаа хамт нөхөр Сталины араас дагах ёстой байхгүй юу. Гэтэл өчүүхэн муу Гришкагийн хойноос дагасан! Яагаад тэгэв? Гришкагийн аугаа их авьяасанд итгээ юу? Үгүй л дээ! Тэрээр ТҮҮНИЙГ хэзээ ч жинхэнэ ёсоор ойлгож байгаагүй, бас нөхөр Сталины нөгөө эгэл байдал, нөгөө бэсрэгхэн чадвар гэгдээд байсан зүйл бол үнэн хэрэгтээ Коммунист академид лекц унших төдийгүй, юунаас урьд олон түмэнтэй ярьж хөөрч, олон түмнийг араасаа дагуулж байгаа жолоодогч хүний даруухан зан гэдгийг ойлгоогүйгээсээ болж л тооцоо алджээ.

Еврей нар ЖОЛООДОГЧ гэж юу болохыг хэзээ ч ойлгоогүй улс. Тэд нар хэзээ ч жинхэнэ ёсоор захирагдаж сураагүй, хэзээнээсээ ийм түүхтэй, чухам энэ л тэдний үндэснийх нь эмгэнэлт явдал болсон юм. Бүх улс түмэн Ромд захирагдаж, тэгснээрээ өөрсдийгөө үндэст-

нийхээ хувьд хадгалан үлдэж чаджээ. Ганц захирагдаагүй нь еврейчүүд. Аливаа шашны бурхан Христос, Магомет, Будда гэхчлэн хүнээр биежин хувилсан байдаг... Гагцхүү еврей нарт л бурхан болгон дээдэлсэн жолоодогч гэж байхгүй, гагцхүү иудейн шашин л бурхныг хүнчлэн дүрслэхийг эс зөвшөөрнө. Тэдний хувьд туйлын дээр нэр хүндтэн гэж байхгүй, тийм учраас л өөрсдийнхөө төр улсыг хамгаалж үлдэж чадаагүй, улсын дээд засаг бол дээд жолоодогчоороо биеллээ олох ёстой шүү дээ. Еврей нар бол хамаг түүхээ маргаанаар өнгөрөөж байгаа улс, тэдний хувьд ардчилал гэдэг бол ердөө л мартаж бололцоотой байхыг хэлж байгаа хэрэг, тэд бол олонхийн саналд хувийнхаа саналыг сөргүүлж тавьж байвал болдог улс.

Гэхдээ жолоодогчийг хүлээн зөвшөөрч түүнд үнэнч зүтгэх чадвартай еврей нар мэдээжээр бий л дээ, жишээ нь Каганович байна. Чухамхүү Каганович л бүр 1929 онд Улаан профессорын дээд сургууль дээр үг хэлэхдээ ТҮҮНИЙГ анх удаа эхэлж жолоодогч гэж нэрлэсэн... Гэтэл Каменев бусдын өнгөний мэдлэг гоё үг хоёрыг илүүд үзжээ. Тэгээд буруутчихсан. Мэдлэг гоё үг хоёр бол жолоодогчийн хувьд багадаа зүйл. Нөгөө хувьсгалын өмнөх сэхээтэн, “зохиолчдын” дундаас гарсан “жолоодогч” нар бүгд хайччихаа вэ? Нөгөө Луначарскийнууд, Покровскийнууд, Рожковууд, Гольденбергүүд, Богдановууд, Красинууд хаачсан бэ? Бас нөгөө Ногинууд, Ломовууд, Рыковууд? Тэд нар алга, тэднээс юу ч үлдсэнгүй. Троцкийд жолоодогчийн зарим нэг шинж байсан. Гэтэл түүний оюуны ихэмсэг занг намын боловсон хүчнүүд тэсвэрлэхийн аргагүйд хүрсэн. Тэрээр оюун ухааныхаа давууг алхам тутамдаа онцолж байсан, өөрсдийг нь тэнэг гэж тооцоход хүмүүс дургүй шүү дээ. Оюун ухааны давуу, эрх дархын давуутай хосолсон цагт л хүмүүс тэр давуу байдлыг хүлээн зөвшөөрдөг юм. Тэдний хувьд оюун ухааны давуу гагцхүү захирагчид байх нь тохиромжтой, тэгвэл тэд нар ухаантай эзэнд захирагдаж байна гэсэн үг, тэгснээр энэ нь тэдэнд доромжлол бус харин өргөмжлөл болж үг дуугүй захирагдаж байгаагаа өөрсдөө зөвтгөн цагаатгаж тэднүүс хүчинд биш ухаанд захирагдаж байгаа хэмээх нэгэн бодлоор сэтгэлээ зогоодог болой. Харин жолоодогч засаглах эрхийг гартаа бүрмөсөн оруулж авгал хүмүүс түүний сайн дурын холбоотнууд, тэрээр тэдний санал бодлыг л томъёолон илэрхийлснээс цаашгүй гэдгийг, тэдэнд үнэмшүүлж чаддаг, энэ тухайд итгэлтэй болгож чаддаг байх ёстой. Троцкий аппаратын ач холбогдлыг ойлгодоггүй байсан шигээ үүнийг бас ойлгоогүй. Мань хүн өөрийгөө жолоодогч гэж үзчихээд гагцхүү өөрөө ганцаараа гоё үг, оюун билэг хоёроороо олон түмнийг араасаа дагуулж чадна гэж бодсон. Хаанаас даа! Олон түмнийг эзэмдэн авахын тулд сайхан ярих төдийгөөр хол явахгүй, хөшүүрэг хэрэгтэй, тэр хөшүүрэг нь аппарат. “Бидэнд хувьсгалчдын байгууллагыг өгөөч, тэгвэл бид Оросыг эргүүлээд тавьчихъя!” гэсэн Лениний нэг гол заалтыг Троцкий хэзээ ч ойлгодоггүй байсан. Лениний “гэрээслэлдээ” бичсэн Троцкийг “большевизмаас гажигч” гэдэг чухам энэ л дээ.

Эсвэл хамтын удирдлагын тухай санааг Ленин үнэн санаанаасаа тоож байсан болох нь уу? Үгүй! Ленин жолоодогчийн ач холбогдлыг ойлгож байсан. “Зөвлөлтийн социалист төвлөн удирдах ёс бол нэгэн хүний удирдлага болон дарангуйлалтай өчүүхэн төдий ч зөрчилдөхгүй... заримдаа ганцаараа илүү их хийчих, бас олонтаа илүү хэрэгцээтэй байдаг дарангуйлан захирагч бол ангийн санаа зоригийг заримдаа хэрэгжүүлдэг юм...” Өөр бас... “Олон түмний дарангуйллыг ерөөс удирдагчдын дарангуйлалд сөргүүлэн тавихдаа... хүрнэ гэдэг бол элэг хөшим утгагүй зүйл, мунхаг явдал мөн...” Ленин үүнийг ойлгож байсан, гэхдээ Оросыг европ аргаар удирдах бодолтой, харин мань Сталиныг азийн аргатай хүн гэж үзэж байсан.

Ленин аппаратын ач холбогдлыг ойлгож байсан. Гэхдээ Засгийн газрын тэргүүний хувьд өөрийнхөө түшиглэж байсан улсын аппаратыг бэхжүүлэхийг бодсоноос биш нөхөр Сталины түшиглэж байсан намын аппаратыг бэхжүүлэхийг бодоогүй юм. Тийм учраас л тэгэхэд түүнийг Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас авахыг санал болгосон. Фермийн эзэнд тулгуурлахад тэд өөртөө эрх мэдэл шаардах учраас Ленин Эдийн засгийн шинэ бодлогын хажуугаар хожим аль нэг цагт илүү өргөн өөрчлөлт хийхээр бодож байсан бололтой. Ленин тиймэрхүү зохицоо хийхэд Троцкий, Зиновьев, Каменев, Бухарин тэр ч атугай Пятаковыг хүртэл боломжийн хүмүүс гэж үзэж байсан хэрнээ ӨӨРИЙГ нь, нөхөр Сталиныг гол “аппаратчин” хэмээн үзэхийн хамт аппарат бэхжихээс болгоомжилж байсан байна. Тэр нь ч зүйтэй. Аппарат бол хөшиж царцах боломжийг агуулсан зүйл, он удаан жилийн хэлхээ холбоогоор нягтарсан аппарат хөшүүрэг байхаа больж үхширсэн тээг болдог. Тариачны, олон үндэстний хоцрогдсон оронд бичиг хэргийн газар хувьсгалын байлдан ололтыг тогтоон барихад хэрэгтэй, гэхдээ бичиг хэргийн газрын өөрийнх нь эрх дарх бүхнийг хамарсан, хяналт шалгалтгүй, хүчирхэг засаг болж хувирдаг учраас нөгөө хувьсгалдаа хор хүргэх аюул занал ийм газарт өөрт нь хоргодож байдаг. Ленин үүнээс зүйтэй болгоомжилж байсан бөгөөд тийм ч учраас “бид хаант Оросоос хамгийн муу юм, хүнд суртал, хүлцэнгүй хашин хойрго байдлыг өвлөж аваад түүнтэй ёстой л хахаж үхэхдээ хүрч байна” гэж нотлон өгүүлдэг байсан юм. Энэ бол үнэхээр тийм. Гэхдээ энэ бол аппаратыг устгах хэрэгтэй, улс төрийн тэнцүүлэг бий болгох хэрэгтэй гэсэн үг огтхон ч биш. Улс төрийн тэнцүүлэг гэдэг бол пролетарийн диктатурын ТӨГСГӨЛ гэсэн үг. Аппаратыг үлдээх хэрэгтэй, аппаратыг бэхжүүлэх хэрэгтэй, гэхдээ аппаратын бие даасан байдлыг үүсэл төдий байхад нь устгаж, хүмүүсийг байнга сольж, тэдний харилцаа холбоог нягтруулж бэхжүүлэхгүй байх хэрэгтэй, байнга шинэчлэгдэж байдаг аппаратад биеэ даасан улс төрийн хүч байхгүй, харин тийм аппарат жолоодогчийн гарт, бүхнийг чадах захирагчийн гарт бол аугаа их хүч болж үлдэнэ. Энэ аппарат засгийн хөшүүргийнхээ хувьд ард түмэнд айдас төрүүлж байх ёстой, харин жолоодогчийн урд бол аппарат өөрөө чичрэн бэмбэгнэж байх ёстой.

Тэрээр ийм аппараттай байх гэж үү? Үгүй ээ, байхгүй. Төв Хорооны бүрэлдэхүүнийг мань хүн аль хэзээнээс нааш өөрчлөх санаатай байсан боловч ӨӨРИЙН ялалт байгуулсан Арван долдугаар их хурал дээр хүртэл энэ ажлаа хийж чадаагүй. Гаргах шалтаг алга гэх маягийн юм яриад байсан учраас Төв Хороонд аль хэзээнэний байх ёсгүй болсон хүмүүсийг үлдээхээс өөр аргагүй болсон. Тэд нарын бие биеэ өмөөрдөг зуршил, тэдний эв нэгдэл, тэдний нягт хэлхээ холбоо саад болоод мань хүн түүнийг гэтлэн давж чадаагүй. Одоо болоо! Энэ аппарат нэгэнт үүргээ гүйцэтгэсэн, ийм хэлбэртэй аппарат одоо түүнд хэрэг байхгүй, өөр аппарат хэрэгтэй, элдвийг шүүн хэлэлцдэггүй, гагцхүү ТҮҮНИЙ дур зоригоос өөр ямар ч хууль мэддэггүй тийм л аппарат хэрэгтэй. Одооны аппарат бол үеэ элээсэн хог новш, мөлжүүр нь дууссан яс. Гэтэл чухам энэ хуучин ажилтнууд л бусдаас илүү бат бэх нэгдэлтэй, бусдаас илүү өөр хоорондоо харилцаа холбоотой, тэд нар байр сууриа зүгээр нэг тавьж өгөхгүй, тэгэхлээр тэднийг зайлуулах хэрэгтэй болно. Тэгтэл тэд нар бол ТҮҮНИЙ эсрэг боссон хүнтэй дуртай цагтаа нэгдэхэд бэлэн нэг насны гомдолтой, үүрд нуугдсан бодит аюултай заналт дайсан болж хувирна. Тэднийг устгаж байх хэрэгтэй болж байна. Тэдний дунд урьд өмнө гавьяа байгуулсан хүмүүс ч байж таарна, гэхдээ нөхөр Сталины ингэснийг түүх өршөөнө. Одоо тэдний хуучин гавьяа зүтгэл намын үйл хэрэгт хортой зүйл болж байна, тэд нар өөрсдийгөө улсын хувь заяаг шийдвэрлэгчид гэж өргөмжилж байна. Ийм учраас тэднийг солих хэрэгтэй.

Солино гэдэг бол устгана гэсэн үг.

Сталин өрөөн дундуураа дахин хэд алхаж цонхны тэнд очиж зогсов... Октябрийн хувьсгалыг Ленин удирдаж, энэ хувьсгалыг Ленин ялуулсан нь үнэн, түүний түүхэн гавьяа чухам энэ. Гэхдээ Ленин хувьсгалыг ялуулж, иргэний дайны галд шинэ засгийг батлан хамгаалсныхаа дараа чухамдаа тууштай марксизмын туршлагаас санаа авсан замаар явсан. Эдийн засгийн шинэ бодлого бол энэ замын эхэн. Ленин феодалын хамжлагат ёсны аливаа үлдэгдлийг устгаж хөрөнгөтний хувьсгалын замыг цэвэрлэн эцсийн хувьсгалч аргыг хэрэглэж байгаад тэр хувьсгалыг гүйцээж хийсэн. Гэтэл Ленин нас барсан. Түүх бол аугаа их найруулагч. Тийнхүү Ленинийг яг цагт нь авч, Оросыг жинхэнэ социалист замаар замнуулах шинэ удирдагчийг оронд нь өгсөн юм. Ингэж замнахын тулд дахиад нэг бус хувьсгал шаардагдана. Тэрээр Октябрийн хувьсгалаас дутуугүй ач холбогдолтой нэг хувьсгалыг одоо хэдийн хийчихээд байна. Хөдөөгийн хувийн аж ахуйтныг устгасан, нударган баячуудын ангийг устгасан, хөдөө тосгоныг фермерүүдийн замаар хөгжих бололцоог язгуураар нь устгасан. Үүнийг хийхэд сая сая хүний амь нас үрэгдсэн, гэхдээ түүх түүнийг өршөөнө. Тэрээр Оросыг аж үйлдвэр, хүнд үйлдвэрийн хөгжлийн замд гаргаж орчин үеийн аж үйлдвэрийн орон, цэргийн хувьд хүчирхэг гүрэн болгон хувиргаж хоёр дахь хувьсгалаа бас хийчихээд байна. Асар их үнээр ингэж хувиргасан, олон хүний амь насыг үүнд өргөсөн, гэхдээ түүх нөхөр Сталины ингэснийг өршөөнө, харин мань хүн Оросыг дайсных нь өмнө арчаагүй дорой буурай хэвээр нь үлдээсэн бол түүх түүнийг өршөөхгүй байсан юм. Одоо засгийн шинэ, онцгой аппаратыг байгуулах хэрэгтэй. Бас хуучныг устгана. Хуучин аппаратыг устгах ажлыг ӨӨРИЙНХ нь эсрэг тэмцэж байсан хүмүүсээс, өөрөөр хэлбэл Зиновьев, Каменев хоёроос эхлэх хэрэгтэй, тэр хоёрыг хэмлэхэд арай хялбар, тэд намын эсрэг тэмцэж байсан, алдаа дутагдлаа маш олон удаа хүлээж байсан болохоор цаашдаа ч хүлээсээр байх болно, тэгэхдээ юу ч хамаагүй хүлээнэ. Тийм болохлоор тэднийг хэн ч өмгөөлж зүрхлэхгүй, Киров ч зүрхлэхгүй.

Киров Ленинградад есөн жил болж байна. Энэ хугацаанд Ленинградын намын байгууллагыг өнгөн талаасаа биш үнэн хэрэг дээр нь Төв Хорооны түшиг тулгуур болгохын тулд тэр нөхөр юу хийв? Үргэлж хэл ам таталж байдаг энэ хотыг бут цохихын оронд тэр нөхөр аргадаж тайвшруулахаар шийдсэн байна. Бут цохино гэдэг бол хуучин аппаратыг шинээр, хуучин ажилтан нарыг шинэ хүмүүсээр солино гэсэн үг. Аргадаж тайвшруулна гэдэг бол хуучин аппаратыг хөндөхгүй үлдээхийн хамт хуучин ажилтан нарыг бас байр байранд нь үлдээж, тэднийг гагцхүү өөрийнхөө талд татаж оруулна гэсэн үг. Нөхөр Киров энэ сүүлчийн замаар нь явсан байна. Яагаад тэгж явах болов? Өөрийнхөө зорилгыг ойлгосонгүй гэж үү? Сайн ойлгож байсан. Гэхдээ намын зорилгыг биш, чухамхүү өөрийнхөө зорилгыг ойлгож байсан, тэгээд Ленинградыг намын түшиг тулгуур болгохын оронд өөрийнхөө түшиг тулгуур болгосон. Тэр нөхөр цаадуулыгаа намын талд татаж оруулаагүй, харин цаадуул нь түүнийг өөрсдийнхөө талд оруулж, түүнээс шинэ удирдагчийг бүтээсэн байна.

Сталин ширээ рүүгээ очиж Ягодагийн мэдээллийг дахин уншив. Ягодагийн төлөөний хүн Запорожец Ленинградын байдлыг өөрчлөх чадваргүй гэдэг нь нээрэн үнэн. Арчаагүй өчүүхэн амьтан!

Сталин үүдний өрөөнийхөө хаалгыг нээж Дотоод явдлын ардын комиссар нөхөр Ягодаг

маргааш өөр рүү нь дуудахыг Поскрёбышевг тушаав.

Үдийн алдад Ангара мөрөн дээр хүрч ирцгээлээ. Аварга мөрний дээрээс нөмрөн дүнхийсэн сүрлэг цавчим хясааны хүрэн, шар, улаан өнгийн шохойлог давхаргууд газрын бүтцийг илтгэнэ. Цагийн дараа Богучаныд орж ирлээ. Тэд энд аж төрцгөөх юм.

Голын эргээр яндангүй халуун усны пингүүд, шонд өлгөөстэй загасны торнууд, гадаснаас уяатай завинууд харагдана. Өргөн гудамжны хоёр талаар харлаж сааралтсан дүнзэн байшингууд эгнэжээ. Дээврийн цавчмал банзан хучлагыг ногоон хөвд бүрхсэн байна. Байшингууд хоорондоо өндөр битүү хашаатай. Хашаан дотроо үүдний довжоотой. Гудамж руу харсан цонхнууд нь хөх буюу хөх ягаан будгаар будсан сийлмэл давхар хүрээтэй.

Малын саравч, задгай хороотой, өвсний хашаа, хэд хэдэн пинтэй цэлгэр том хашаа руу улаачин тэрэгтэйгээ явж орлоо. Харин мал ахуй байхгүй, хэдэн тахиа л өтөг онгичиж байв. Улаач нэг торниун байшингийн үүдийг нээхэд исгэлэн үнэр хамар дэлсэж гар хийцийн болхи ширээ, хана дагуулан тавьсан вандангууд нүднээ тусав. Бэлэвсэн эмийн ядмаг оромж.

Эзэд нь гэж гурван хүн байх ажээ. Махир таягтай атиралдсан эмгэн сандал дээр суугаад улсын хөдөлгөөн бүрийг сэтгэл түгшин харна. Түүний охин гэж хэнхдэг нь цаашаа орж, гэдэс нь шолхойсон, балиар хормогчтой дөч эргэм насны хүүхэн хэлгүй юм шиг таг чиг байна. Энэ хүүхний хүү арван зургаа орчим настай атигар биетэй, царай дорой хөвгүүн байна.

Юм хумаа хураачихаад Дотоод явдлын ардын комиссарын газрын районы бүрэн эрхт төлөөлөгч рүү явцгаав. Тэр нь Баранов хэмээгч албаны ихэмсэг дүртэй бүдүүн хүн байв. Царайг нь харваас өвөлжингөө унтсан, мөн цаашаа унтвал унтаад байх бололтой, даанч улсын ажил болохгүй юм гэж байх мэт. Тэрээр дугтуйтай бичгийг задалж, хөмсөг зангидан уншиж үзээд хүн болгонд оршин суух газар товлож өгөв. Ивашкин Богучаныд үлдэж, Володя Квачазе Ангара уруудах болж, бусдыг нь дээш гол өгсүүлж, Карцевыг Чадобец тосгон руу, Борис, Саша хоёрыг өөр районд Кежма гэдэг тосгон руу, тэр районы бүрэн эрхт төлөөлөгчийн мэдэлд шилжүүлэхээр болов.

–Ийм юм л даа, надад “Ангийн үс бэлтгэх газрын” эндхийн салбарт орох томилолт байна хэмээн Борис учирлаж, –Нөхөр Хохловоос нөхөр Косолаповт ирүүлсэн шийдвэр бий гэв.

Хохлов бол “Ангийн үс бэлтгэх газрын” тойргийн конторын дарга, Косолапов нь Богучанын конторынх юмсанж. Гэхдээ Борис Баранов хураагаад авчих байх гэж болгоомжлоод Хохловын захидлыг үзүүлсэнгүй.

-- Хохлов бусдын ажилд дэмий оролцож байна хэмээн Баранов хөмсөг зангидаж,

–Шуудангийн завь ирэхээр Кежма руу явцгаагаарай гэв.

Володя өөрсдийнхнийгөө хайхаар явав.

Ивашкин Богучаныд хэвлэх үйлдвэр ажиллуулах санаатай байгаа, гэтэл өрөгч байдаггүй гэнэ, өрөгчид ч хаа ч ховор доо хэмээн дорхноо сэргэж хосгүй мэргэжилтэйдээ бахархах сэтгэлд

автав.

–Та хэвлэх үйлдвэрийн тухай хаанаас мэдээ вэ? гэж Саша гайхшран асуув.

–Канскт сонссон юм гэж Ивашкин тодорхойгүй юм хэлчихээд сууц хайхаар гүйгээд алга болов.

Тэрээр энэ ажлыг нь хэн нэгэн хүн авчихаж магадгүй хэмээн болгоомжлоод энэ тухай замын турш юу ч дурсаагүй гэж бодоход эвгүй санагдана.

Борисын урам хугарчээ. Хаа ч байгаа Кежма билээ, дахиад гурван зуун километр явна, тэнд сул орон тоо байгаа эсэх нь бүү мэд, тийш нь бас албан бичиг авчих санаа төрсөнгүй, тэнэг толгойд чинь.

–Ямар ч байсан би Косолапов дээр очъё, тэр яаж ийгээд аяыг нь олж магадгүй гэж Борис хэлэв. -- Баранов хонь хэмээх нэрэндээ таарсан эр ажээ.

–Саша, Карцев хоёр айл руугаа буцав. Карцев бүр сульдаж гүйцжээ. Айлдаа арайхийн хүрч, вандан бараадаад уух юм гуйлаа. Тэрээр халууран дагжиж байсан тул Саша түүнийг хучиж өгөөд эмгэнээс,

–Танайд буцалгасан ус бий юу? гэж асуув.

–Чанасан ус уу? Тэр тогоонд байна.

Эмгэн тэрхэн буландаа ууль шувуу гэлтэй сууна.

–Замдаа туйлдчихжээ. Зүгээр. Залуу хүн, эдгэчихнэ. Юм гоочилцгоох уу?

–Нөхдийгөө ирэхээр больё.

Володя эхэлж ирээд ууттай юмаа авч танилындаа буухаар боллоо. Сургуулийн цаад талд гурав дахь байшин гэж хэлчихээд яваад өгөв.

Дараа нь Борис ирэв. Косолапов яаж ч чадахгүй, Барановоос бүх юм шалтгаална гэнэ, тэр муу мунаг толгойгоос хүний амьдрал хамаарах гэж байх уу? За яахав, муу түрүүлгээ хармар!

–Саша, би харин ч гэж баяртай байна. Би танд дасчихсан байна. Замд цуг гарсан юм чинь замаа цугтаа л дуусгацгаая.

Тэгээд Кежмад яаж ажилд орох, Сашад яаж ажил олж өгөх тухай хэдийн яриа үүсгэж Кежмагийн районы “Ангийн үс бэлтгэх газрын” даргын сэтгэл зүрхийг эзэмдэж авахын тулд тэндхийн холбогдолтой зарим тоо баримтыг нэхэн санаж эхлэв.

Ивашкин хүрч ирж хоол ундтай хямд төсөр толгой хоргодох газартай болсноо мэдэгдэж, эндхийн цалин сайн, бас умард нутгийн нэмэгдэл авна, тийм учраас мань хүн гэртээ мөнгө гуйвуулж дөнгөнө, ая нь таарвал гэр бүлээ ийш нь дуудаад аваад ирж ч магадгүй хэмээв.

Тэгээд өнөөдрийнхөө хоолны мөнгийг төлчихсөн гээд тэдэнтэй хоол идэлгүй явахаар болов.

–Хүүхдүүд минь, би харайлгаж үзье, намайг хүн хүлээж байгаа.

Хэзээ явахыг нь ч асуусангүй, хаягаа ч үлдээсэнгүй, захиа занга ч хүссэнгүй, өөрөө ч бичнэ гэсэнгүй... “Хүүхдүүд минь, би харайлгаж үзье, хүн хүлээж байгаа”.

–Хүмүүс ингэж л салдаг байна гэж Борис өгүүлэв.

–Таныг тэврээд уйлчихсангүй шүү хэмээн Саша тамшаалав.

–Та бас анзаараа юу? Эр хүн! Чадварлаг хүү байна.

Сүүн зутантай хайрсан өндөг нэг тавагнаас хувааж идчихээд хоёулаа шуудан дээр очиж тэдний нэрээр ирэх аливаа зүйлийг Кежма руу явуулж байхыг хүсээд өргөдөл бичиж үлдээв. Саша ээждээ бие гойд сайн байна, Ангара гэж аварга том мөрөн, дутаж гачигдаж байгаа юм огт алга, захиаг Кежма руу өөрөө авагчаар бичих хэрэгтэй гэсэн захидал бичив.

Тэгээд айлдаа буцаж ирцгээв. Гудамжинд анч ноход цагариглан хэвтэх бөгөөд хажуугаар нь дамнуургатай хүүхэн өнгөрөх буюу хашаанаас бөөн хүүхдүүд пижигнэн гарч ирж байхад хүртэл толгой өндийх янзгүй байх ажээ.

–Шуудангийн бүсгүйг л энэ нутгийн хатагтай гэж тооцохгүй бол өчүүхэн ч гэсэн боломжийн юм харагдахгүй байх чинь вэ... хэмээн Борис өгүүлж, –Энэ зуур хэлэхэд энд тэмбүү элбэг шүү, тун болгоомжтой байгаарай. Бас нүдний үрэвсэл гэж бий, эднийхний нүүр гарын алчуураар арчиж заяа нь болохгүй шүү! За нөгөө гол асуудлын тухайд, манай байшингийн хавиар эргэлдээд байгаа нэг охиныг та анзаарсан уу? Нэлээн шанаархуу, зүгээр охин гэв.

Саша түүнийг айлынх нь нөгөө хүүтэй ярилцаж байхыг харжээ

-- Тан руу нүд хаяад байсан шүү гэж Борис нэмж хэлэв.

–Бүр нялх амьтан байх чинь билээ.

–Яагаад тэр вэ? Арван зургаан нас бий. Ер гологдохгүй. Эд нар чинь дараа нь хүнтэй суугаад тэрэгний морь шиг болчихдог юм. Ажиглаарай л даа.

–Бага насны хүүхдийг хүчирхсэн болно хэмээн Саша инээд алдаж, –Би ч тавин наймдугаар зүйлээрээ дуусъя чи минь гэв.

Байшингийн манаасан дээр нөгөө охин сууж байв. Биеэр багавтар ч цэх нуруутай, чийрэг хөлтэй, цэвэрхэн эвлэг нүүртэй, огцом духтай, зузаавтар уруултай охин аж. Яльгүй орсгордуу шүд нь хамниган буюу монголжуу янзтай. Цамцаа битүүлэн товчилж, хөдөөгийн урт банзал нь тавхай нь уллан сайртсан нүцгэн хөлийнх нь шагайгаар татах ажээ. Тэрээр бохь зажлан, жижигхэн бор нүдээр Саша руу инээмсэглэн харж байв.

–Юу гэж инээгээ вэ? хэмээн Саша асуув.

Охин пирхийтэл инээд алдсанаа гараараа амаа таглан босон харайж хашааны хаалга саваад гүйж одов. Гэхдээ хашааны завсраар араас нь шагайгаад байгааг Саша ажиглажээ.

–Зэрлэг охин, гэхдээ цэврүү шиг сайхан амьтан, уран баримал л гэсэн үг гэж Борис өгүүлэв.

Оройн хоолонд жигнэсэн шар манжинг таташгаж, овьёосны зутантай хольсон бантан өгөв. Дахиад л гэрийн эзэгтэй, тэдний хүү энэ тэртэй цөмөөрөө нэг түмпэнгээс халбагадлаа. Эмгэн мах, сүү нүдний гэм хэмээгээд гэрт эр хүнгүй болохоор загасчлах ч амьтан байхгүй, тэгэхлээр ядахдаа загас ч алга гэж гаслан халаглав.

Оройн хоол идэж байхад нөгөө хөрш айлын охин дахиад үзэгдлээ. Тэрээр хаалга онгойлгосноо Сашаг хармагц хаалгаа хаачихаад үүдний пинд чимээгүй болчихов.

–Яагаад нуугдаад байгаа юм бэ, могойн зулзага чинь! хэмээн эмгэн зандрав. Цаадах нь үүдний пинд чимээгүй зогсоор л байв. - Солиотой охин хэмээн эмгэн тайлбарлаж, –Лукерья гэдэг юм, Лукешка, ороод ир. Энэ хотынхонд сонин идэх юм байна гэж эмгэн дахин зандрав.

Саша үлдсэн хиамаа Карцевт зориулан зүслээ.

Лукешка орж ирээд үүдэнд зогсчихов.

Эмгэн түүнийг намхан нуруутай юм болохлоор,

–Одой охин, аль ч төрлөөсөө, эцгээсээ ч, эхээсээ ч одой амьтан... хэмээгээд, - Ах нар чинь хайчсан бэ? гэв.

–Бүү мэд гэж Лукешка хариулснаа Саша руу нүднийхээ булангаар харж, –Гэхдээ ойд яваа гэв.

–Булгалсан хожуул, гишүү түүхээр явсан уу, бас л архидаж яваа юу, хундага гэдэг чинь уруу татдаг эд шүү. Эцэг чинь хамт яваа юу?

–Хамт яваа...

Лукешка Карцев руу дохиж,

–Бие нь муу байгаа юм уу? гэв.

–Тийм, өвчтэй хүн үглэх юмаа үглэчихсэн. Хэнийг үглэсэн юм бол? Сүнс нь биеэсээ зайлж байна хэмээн эмгэн хариулаад,

–Юу гээд зогсоод байгаа юм? Суугаад ярилц, ямар сайхан хархүү байгааг харахгүй юу гээд Саша руу дохиж заав.

Гэвч урт банзлынхаа гадуур цамцаа гаргасан, хөл нүцгэн Лукешка үгэнд нь орсонгүй, бохио зажлан Саша руу инээмсэглэсэн харцаар жишүүхэн харж үүдэнд зогсоор байв. Туяхан биеэс нь гол ус, өвс ургамал ханхална. Ажил, гэр орон, хүүхэд шуухдад дарагдаж амжаагүй сэргэлэн цовоо, хүч тамир оргилон бүхий ахархан үе хөдөөгийн охидод байдаг, бүсгүй одоо хэр чухам

тэр насан дээрээ байгаа агаад эцэг эх нь цуг, бас ах нар нь авгайтайгаа хамт унтдаг ганц тасалгаатай байшин, тосгоны бүдүүлэг гудамж хоёроор хүмүүжсэн болохоор мэдэхгүй юм гэж байхгүй, ичих зовохоо мэдэхгүй гэнэн цагаан амьтан болой.

Саша хэрчим хиам сарвайж,

–Идэж үз л дээ гэв.

Лукешка зогссон газраасаа хөдөлсөнгүй.

–Аваач, гудар! гэж эмгэн хэлэв.

Лукешка хиамыг авлаа.

–Танайхан уржигдар загасанд явсан уу? гэж эмгэн асуув.

–Явсан.

–Их бариа юу?

–Хоёр хувин дүүрэн барьсан.

–Чи хэдтэй вэ? гэж Саша асуув.

–Хэн гэнэ ээ? гэж Лукешка лавлаж асуув.

–Чи хэдэн настай вэ?

–Хэн мэдэхэв... Гэхдээ арван зургаа...

–Хүн хуурах нь, манай Ванька арван тавтай, чи ч бас арван тавтай гэж эмгэн зөрөв.

Лукешка мөрөөрөө хатавч шөргөөгөөд юу ч хэлсэнгүй.

–Лукешка!!! гэх дуу гудамжнаас хадаад явчихлаа.

–Чамайг хашгичаад байна гэж эмгэн өгүүлэв.

–Намайг л гэж хариулсан боловч Лукешка дороосоо хөдөлсөнгүй.

–Лукешка!

–Өө оргодол! гэж зүхээд Лукешка хаалга савж гарлаа.

–Аятайхан бүсгүй шүү, чи нэг баадан бэлэглэчихвэл цаадах чинь чамтай зугаална гэж эмгэн Сашад хэлэв.

–Баадан гэж юу вэ?

–Яахав, алчуур гэсэн үг.

–Сонин хэрэг байна хэмээн Саша жуумалзав.

Карцев шөнө нь ёолон гийнаж амьсгаа нь бахардан, өөрөө өндийж чадахгүй, жаахан суугаа байлгахыг гуйж хонов.

Өглөө нь Саша, Борис хоёр эмнэлэг рүү явлаа. Эмчид зөндөө хүн үзүүлэхээр жагсжээ. Хүмүүс байшингийн хонгилд төдийгүй үүдний довжоогоор сууцгааж байв. Соловейчик эмчийн өрөө рүү шууд орж явчих нь тэр. Саша араас нь орлоо. Залуухан эмч Борисын хэлэхийг сонсож цөллөгийн хүний тухай яригдаж байгааг мэдмэгц районы бүрэн эрхт төлөөлөгчөөс зөвшөөрлийн бичиг авчир гэжээ.

–Хүн үхэх гэж байхад ямар юмны чинь зөвшөөрлийн бичиг вэ? гэж Саша ширүүн хэлэв.

–Ямрыг нь Баранов мэднэ гэж эмч хариулав. Баранов нойрмогтсоор тэдний өөдөөс хашаандаа гарч ирээд, юу болсныг зан муутай асууснаа, нэг цаасан дээр “Районы эмчид. Өвчтөн зах. цөллөгдөгч Карцевыг үзэж өг” гэж дурамжхан сараачиж өгөв.

Тэр хоёр эмнэлэг рүү буцаж ирэв. Борис дахиад оочергүй дайран орж нөгөө зурвасаа өглөө. Хүнээ үзэж дууссаны дараа очно гэж эмч хэлэв.

Тэрээр үдэш ирж Карцевыг үзээд ерөнхийдөө бие муудсаны хамт ерөөсөө уушиг нь хавагнаж, бас уушигны хатгалгаа болсныг оношлов. Хүчилтөрөгчийн жинтүү хэрэгтэй, гэтэл тэр нь байхгүй, эмнэлэгт хэвтэх шаардлагатай, гэтэл аравхан ортой эмнэлэгт хорин хүн хэвтэж байгаа гэнэ. Тэгээд эм бичиж өгөөд унтахынх нь өмнө халуун сүү сайн уулга гэж хэлжээ. Гэвч эмчийн эзэнгүй ширүүн харцаар Карцев түүний хувьд шийдчихсэн хүн байна гэдгийг Саша ойлголоо.

Өглөө нь Карцевын бие жаахан сэргэж тэрээр Барановыг дуудаж өгөхийг гуйв.

–Чи тэрүүгээр яах нь вэ? хэмээн Саша гайхчихав.

–Очоод дуудчих, энд хүчилтөрөгч ч бий, бүх юм бий. Та нар яваад ир, тэр наашаа ирэг гэж Карцев хөхүүлэн ханиалгаж хахан цацан өгүүлэв.

Тэр хоёр явлаа. Замдаа Борис Володя Квачазе руу орохыг санал болгож,

–Цаадах чинь түүнтэй ярьж чадна гэв.

Володя тэдний үгийг сонсохдоо тайван, бараг санаа зовж байна уу гэхээр байв. Нөгөө Чуна голын тэнд Карцевыг хүйтэн хороонд орхиж гэм хийснээ цагаатгах гэж байгаа юм болов уу? Бараг л үгүй биз... Харин өөр нэг бодол байж магадгүй юм. Юу гэвэл, дарга нартай хэрэлдэж өөрийгөө нотлон харуулах нэг шалтаг, зүгээр ч үгүй, цөллөгийн хүнд эмнэлгийн тусламж үзүүлье гэхгүй байгаа ноцтой шалтаг байна гэж бодсон байх талтай.

–Карцев Барановыг өөр лүүгээ ирүүлээч гэж гуйсан юм.

–Юу? хэмээн Володя Саша руу эргэхэд царай нь жигтэйхэн аймаар харагдав. - Барановыг ир гэж гуйсан!

Мань хүний хоолой чичрэн ингэж бачимдаж дүрэлзэхээрээ гүрж аялга нь улам тод болдог нь мэдэгдээд ирлээ.

–Бие нь тийм байгаа юм чинь өөрөө Баранов руу очиж чадахгүй шүү дээ.

–Тэр этгээд Барановыг өөр лүүгээ ирүүлээч гэсэн гэнэ ээ! хэмээн Володя Саша руу муухай харан өгүүлээд,

–Тэгээд та хоёр тэр даалгаврыг нь биелүүлэх гэж яваа юм уу? гэв.

Түүний эвлэршгүй янзнаас Саша бүр залхаж,

–Чи юу гэж над руу ширтээд байна, анх удаагаа хараа юу? гэв.

–Володя тайвшир. Саша энд ямар ч холбогдол байхгүй гэж Борис хэлэв.

Володя хэсэг зуур чимээгүй байснаа,

–Карцев бол өдөөн хатгагч тагнуул гэж заналтай өгүүлэв.

–Яагаад тэр вэ?! хэмээн Саша мэл гайхаж,

–Тэр чинь гурван жил улс төрийн хорионд суусан, өлсгөлөн зарлаж байсан, судсаа огтолж байсан шүү дээ гэв.

–Суугаа л биз, өлсөө л биз, судсаа огтлоо л биз! хэмээн Володя хашгичин өрөөн дундуур нааш цааш гүйж, –Янз бүрийн амьтан сууж байгаа, есөн шидийн амьтан. Тэгэхлээр бүгдтэйгээ хамт өлсгөлөн зарлах ёстой... Түүнийг яах гэж Москва руу аваачсан юм бэ? гэв.

–Түүнд цөлөх ял өгсөн гэж Борис өгүүлэв.

–Тэгээд юу гэж?! хэмээн Володя дахин хашгичиж, –Ийм юмнууд цөллөгийн газар ч бас хэрэгтэй. “Жаахан холдмогц алдаагаа хүлээх болоо юу? Тэгэхгүй шүү, уучлаарай, буруугаа хүлээх чинь багадна ажил хэргээр нотол! Бидэнд туслахууд хэрэгтэй...” гэж хэлээ л дээ гэв.

-- Хэрвээ тэгсэн бол Баранов түүнийг Чадобец явуулахгүй энд нь Богучаныд үлдээх ёстой биш үү гэж Саша зөрөв.

–Баранов юу ч мэдэхгүй байгаа! Дугтуйн дотор бидний зөвхөн танилцуулга байсан. Харин нөгөөдөх бол дараа нь тусгай шуудангаар ирнэ. Карцев өөрийн хүн гэдгээ түүнд тайлбарлах, өөрийг нь эмчлэх хэрэгтэй, аврах хэрэгтэй гэж хэлэх гэсэн хэрэг. Верхнеуральскт байсан хоригдлуудыг тэндээс нь цөмийг нь шорон, хорих газрууд руу нь явуулсан хэрнээ ганцхан мань хүнийг Москва руу аваачсан! Яах гэж тэр вэ? Третьяковын зургийн үзэсгэлэн үзүүлээ юу?

–Чамтай санал нийлээгүй хэн боловч эсвэл чоно, эсвэл өдөөн хатгагч байх болох нь ээ, бид хоёр Баранов руу явлаа гэж Саша өгүүлэв.

–За яахав, тийм ажилд оролц л доо оролц! гэж Володя занх янзтай хэлэв.

–Бүү сүрдүүл! Тэр байтугай юм үзлээ!

–Чи хэнийг үзсэн юм бэ? хэмээн Володя дахин хашгичиж, — Чи юу ч үзээгүй. Ээжийн эрх жулдрай! Чи дөчин градусын хүйтэнд мод хийж үзээгүй, хүмүүс цасан дээр яаж үхэж байхыг хараагүй. Яаж цусаар ханиаж байхыг үзээгүй. Карцевыг өрөвдөж гэнэ! Тэгвэл чи Карцевчуудын үхэл рүү явуулж байгаа улсыг өрөвдөхгүй байна уу? гэв.

–Хамгаас түрүүн чамайг л өрөвдөж байна гэж Саша хэлэв.

Барановын байшин руу ойртож очмогц Борис зогтусав.

–Саша, хоёулаа бүх юмыг сайтар бодож үзье. Володятай санал нийлэхгүй байж болно, гэхдээ түүний ярьж байгаа юманд учир начир байна гэдгийг үгүйсгэх үндэс алга. Карцевт яагаад Баранов хэрэгтэй болчихов? Эмнэлэгт хэвтэх гэж тэр үү? Тэр тухай бид нар ч шаардсан чадна шүү дээ. Тэгвэл яах гэж дуудуулав? Саша, та бол дөнгөж эхэлж байгаа хүн, би бол энд нэг хэсэг ноололдчихоод байна. Ингэж сэжиглэхээс аймшигтай юм гэж огт байхгүй, ийм юм чинь нүд ирмэхийн зуур тархчихдаг юм. Гэхдээ бүр нэг насаар шүү, үгүй гэдгийг нотлохын арга байхгүй. Би бол эмнэлэгт очиж Карцевыг асарч, өтгөн шингэнийг нь зөөхөөс авахуулаад юу ч хийхэд бэлэн байна... Харин Баранов тэр хоёрын болзоог залгуулах хүсэл алга.

–Би ганцаараа явна аа гэж Саша хэлэв.

Борис бодолхийлснээ,

–Хоёулаа ингэе. Барановоос эмнэлэгт хэвгүүлэхийг шаардъя. Харин Карцев түүнийг дуудуулсан гэдгийг хэлэхгүй байя. Тэгээд эмнэлэгт хэвтсэн хойноо түүнд Баранов нь хэрэгтэй юм бол эмчээр дамжуулан албан ёсоор дуудуулна биз гэж санал болгов.

–Би та нарт эмч өгсөн, өөр яах гэв? гэж Баранов унтууцан асуув.

–Түүнийг эмнэлэгт хэвгүүлэх хэрэгтэй байна.

–Сул ор байхгүй гэж хэлээд байна шүү дээ.

–Хүн үхэх гэж байна.

–Үхэхгүй ээ.

–Харин үхэх юм бол та түүнийг эмнэлэгт хэвгүүлээгүй гэдгийг бид Москва руу мэдэгдэнэ шүү.

–Панкратов, та энд ер нь муугаар эхэлж байна шүү хэмээн Баранов хорсолтой хэлэв.

Гурван цаг орчмын дараа эмнэлгийн морин тэрэг нөгөөдүүлийн байшин руу ирэв. Саша, Борис хоёр Карцевыг өргөж гаргалаа.

Зургаан сарын халуун өдөр өндөрлөж голын зүгээс сэвшээ салхи сэрвэгнэнэ. Карцев нүд нь аниатай хэвтэх агаад амьсгаа нь овоо жигд, намуухан байлаа.

Орой нь жижигхэн хөлдөө жимбийтэл угласан бойтог гуталтай Лукешка дахиад байшингийн манаасан дээр сууж байв. Зангидсан тод алчуур нь хоёр мөрийг нь бас бүрхжээ.

Тэрээр Сашаг дэргэдээ суухыг урих мэт жаахан зайчлан суув. Саша суулаа.

—За юм ярь, Луша. Чамайг Луша гэдэг биз дээ?

—Лукешка л гэцгээдэг юм.

—Манайхаар бол Луша. Би чамайг Лушенька л гэж байя.

Цаадах нь алчуураараа амаа таглав.

—Лушенька гэхэд аятайхан байна уу?

Охин амнаасаа алчуураа авахад нүд нь инээмсэглэн байв.

—Чи ажил хийдэг үү, сургуульд байдаг уу?

—Сурдагаа сурчихсан.

—Хэддүгээр анги төгссөн?

—Гурав, дөнгөж л.

—Уншиж, бичиж чадах уу?

—Чаддаг байсан, одоо мартчихсан.

—Ажил хийдэг үү?

—Би гал тогоо л барьдаг юм. Чи хаа аж төрөх юм бэ?

—Кежмад.

—Өө... хэмээн охин урамгүй уулга алдаж, — Хол юм. Манай энд цөллөгийнхөн аж төрж байгаа, зөндөө бий.

—Чи Кежмад очиж үзсэн үү?

—Үгүй, ойгоос цааш явж үзээгүй.

–Баавгайнаас айдаггүй юм уу?

–Айдаг. Ноднин бид нар ойд жимсэнд явсан юм, тэгсэн чинь нэг баавгай гэнэтхэн гарч ирээд хүрхрэх нь тэр, ой мод доргиод явчих шиг болсон. Бид нар хашгиралдан завь руугаа харайцгаалаа. Жимс хайран байвч хүнд гэдэг нь учиргүй. Тэгээд хаячихлаа. Баавгай явах гэж майхганаад нэг их хурдан биш. Бид нар ч сэлүүрдэж гарлаа, тэгсэн нөгөө араатан чинь ус руу ороод ирдэг байгаа даа... Арайхийж сэлүүрдэж байж зугтацгаасан, тэгээд ухаан алдатлаа айж уйлаан майлаан болцгоосон... Ээ мөн, хэцүү газар... Хувхай хоосон ирцгээсэн. Одоо айгаад тэр аглаг газар луу явахаа больсон.

Тэрээр инээд алдан дориун ярьж байвч бас ичингүйрэн алчуурынхаа үзүүрээр амаа байн байн таглах ажээ.

–Надтай Кежма явах уу? гэж Саша асуув.

Охин инээхээ больж түүний өөдөөс харлаа.

–Аваад явбал явна.

–Тэгээд тэнд очоод юу хийцгээх билээ?

–Аж төрөхгүй юу. Чи Кежмад хэдий хэр болох юм бэ дээ?

–Гурван жил.

–Гурван жил аж төрцгөөе, тэгээд чи явна биз.

–Чи яах бэ?

–Би юу? Үлдэнэ. Энд цөмөөрөө л тэгдэг юм, жаахан аж төрж байгаад дараа нь яваад огно. Харин чи Ангарын хүн болчих юм уу?

–Үгүй ээ, болохгүй.

–Маргааш Сергунькагийн арал рүү явна. Бидэнтэй яваарай.

–Яах юм бэ?

–Хонуугаар явах юм гэж охин ичих нүүргүй гэнэхэн царайлж хариулав.

–Лукешка! хэмээх дуу хамар хашаанаас часхийгээд явчихав.

–За, тэгээд явах уу?

–Бодож байж больё.

–Өө яасан их боддог эр вэ хэмээн Лукешка инээд алдсанаа гүйгээд явчихлаа.

Авсан дотор харуулдас үлджээ. Саша цэвэрлэж хаях гэсэн боловч Борис,

–Гаргаж хаяж болдоггүй юм, та мэдэхгүй гэж үү? гэв.

Саша анх удаа хүн оршуулж байгаа болохоор тэр тухай мэдэхгүй байжээ.

Морин тэрэгчин, үйлчлэгч хоёр доошоо хүүрний зоорь луу орцгоов.

Эмч үүднийхээ довжоон дээр гарч ирээд үхэж байгаа Карцевыг харж байсан нөгөө ширүүн харцаараа Сашаг хараад,

–Нас барсан тухай бичгийг районы бүрэн эрхт төлөөлөгчид шилжүүлсэн гэж хэлэв.

Саша, Борис хоёр хариу дуугарсангүй, тэд нар бичгээр яах вэ дээ, хэнд түүнийг явуулах вэ?

Эмч явахгүй тэднийг харан зогссоор байв. Тэрээр түүний үе тэнгийн хүн аж.

Үйлчлэгч, морин тэрэгчин хоёр цогцсыг гаргаж ирж авсанд хийв.

Тагийг нь хадлаа. Морин тэрэг хашаанаас гарав. Хажууд нь тэрэгчин намхан эр алхалж явсны араас Саша, Борис хоёр дагав. Тосгоны урт гудамжаар хар саарал дүнзэн байшингуудын хажуугаар өнгөрч, мөн тийм хар саарал гудамж руу эргэн тосгоноос гарч, хаалга цонх нь хадаатай модон сүмийг чиглэн хажуу өөд өгсөв. Тэр сүмийн цаана оршуулгын газар байгаа ажээ.

Хүрз аван ухаж эхэллээ. Газар өнгөн дээрээ зөөлхөн байснаа жаахан гүнзгийрмэгц үелсэн мөсөн давхаргатай хөлдүү цэвдэг болж ирэв.

Цөллөгийн замд санаандгүй цуг явж таарсан Карцевын амьдралын зам ингээд төгсдөг байжээ. “Серп и молот” (Алх, хадуур) үйлдвэрийн ажилчин, комсомолын ажилтан, Верхнеуральскийн улс төрийн хорих газрын хоригдол, цөллөгийн хүн. Володягийн зөв үү? Карцевыг юу ингэхэд хүргэв? Алдаагаа наманчлах, чин үнэнээсээ гэмшсэнээ нотлох гэсэн хүсэл нь үүнд хүргэв үү? Эрх чөлөө амласан юм болов уу? Эсвэл ерөөсөө л хулчгар дорой зан уу?

Эдгээр асуултын хариу алс холын Сибирыг, орчлонгийн мухарт Карцевтай цуг булшинд орох нь тэр.

Гэхдээ энэ бүхэн үнэн байлаа ч гэсэн Саша тэртэй тэргүй тийм Карцевыг мэдэхгүй. Тэрээр бие муу, зовж цөхөрсөн нэгэн хүнийг л мэдэж байгаа.

Тэрэгчин хүрзээ орхилоо.

–Болно. Баавгай хүрч ухаж чадахгүй.

Авсаа тэргэн дээрээс буулгаж, оосор дээр тавиад ухсан шинэ шороон дээгүүрээ аятайхан давуулж нүх рүү хийлээ.

Дараа нь оосроо сугалж аваад авсаа шороогоор булав. Ажил дууслаа. Тэрэгчин тэргэн дээрээ харайж суугаад, жолоогоо огцомхон дугтарч тосгоны зүг хатируулан одов. Саша, Борис хоёр булшны дэргэд үлдлээ.

–Үгүйдээ банзан дээр нэрийг нь бичиж пайз хийх юмсан гэж Борис хэлэв.

Гэвч тэд нарт сарампайн өөдөс, харандаа хоёрын аль нь ч байсангүй.

Уулнаас Ангарын бараа тэртээ алсад харагдаж, тэр мөрөн их усаа хадан хясаа, ой моддын дундуур нэгэн танихгүй мэдэхгүй газраас нөгөө танихгүй мэдэхгүй газрын зүг хуйлруулан элдэх авай. Газар тэнгэрийн савслаганаа ус яг тэнгэрийн өнгийг олж бурхан усыг уснаас салгах хатуу бодис бүтээгээгүй юм шиг хурмасттай нэгсэн нийлэх ажээ.

Сашад уй гашуу, баяр хөөр хосолсон нэгэн совин татаад явчихлаа. Эль хуль оршуулгын газар уйтгар гунигт авган цөхрөн зогсож байснаа учирсан зовлон зүдгүүр нь маш өчүүхэн зүйл гэдгийг гэнэтхэн тов тодхон ухаарлаа. Энэхүү байгалийн аугаа их үүрдийн заяа түүний өнөөг хүртэл дээдлэн аж төрж явсан шүтээнээс эрхбиш эрхэм нандин зүйл буй гэх итгэлийг сэтгэл зүрхнээ чангалан байна. Хүнийг цөллөгт явуулж, ийм аргаар түүнийг няцааж авна гэж бодож байгаа хэн боловч төөрөлдөж байгаа хэрэг. Алж болно, няцааж болохгүй.

–Үүнийгээ унших!

Ягодаг өөрийнхөө ирүүлсэн хамгийн сүүлчийн мэдээллийг уншиж байх хооронд Сталин түүнийг сонжин ажиглав. Хамар дороо Гитлер шиг чимх сахалтай, нэвчмэл улаан өнгийн болхи хавчиг нүүртэй, хулмалзсан муухай харцтай, царай дортой нөхөр!

Тэрээр түүнийг бүр 1929 онд сонгож авсан билээ. Менжинский хүнд өвчтэй, хэрэг дээрээ ажлаас хөндийрчихсэн тул Намын Арван долдугаар их хурал дээр түүний орлогч Ягодаг оронд нь Төв Хорооны бүрэлдэхүүнд оруулжээ. Менжийнскийг Улс төрийн ерөнхий газрын даргын албан тушаалаас чөлөөлж оронд нь Ягодаг томилж болох байсан боловч Менжинскийг цөмөөрөө Феликс Зержинскийн залгамжлагч гэж үздэг учраас ингэж соливол буруу ойлголт төрүүлж мэдэх байжээ. Менжинский сарын өмнө нас барсан. Дотоод явдлын ардын комиссарын газар (ДЯАКГ) байгуулах тухай аль хэдийн бэлтгэсэн Улс төрийн Товчооны шийдвэрийг тэр даруй ёсчлон гаргажээ. Тэгээд бүрэлдэхүүнд нь Улсыг аюулаас хамгаалах ерөнхий газар, сэргийлэх, хилийн болон дотоодын цэрэг, засан хүмүүжүүлэх газар мөн түүнчлэн гал түймрээс хамгаалах газар, иргэний 1-р бүлийн байдлыг бүртгэх товчоо энэ тэрийг оруулж Дотоод явдлын ардын комиссараар Ягодаг томилжээ.

Ягода намын ахмад гишүүн, мэргэжлийн чекист бөгөөд улс төрийн бодлоготон биш Улс төрийн Товчооны гишүүн биш “төвийг сахисан” этгээд учраас намын удирлагын хүчний тэнцвэрийг алдагдуулахгүй тул түүнийг томилох асуудлаар Улс төрийн Товчоон дээр зөрөлдөөн гарсангүй.

Ягода Свердловын зээ дүүтэй суусан бөгөөд Свердлов тухайн үедээ хүргэнийхээ авьяас билгийг нэг их ойшоож үзэхгүй, түүнийг эхлээд “Деревенская беднота” (“Хөдөөгийн ядуус”) сонины редакцид, дараа нь Бүх Оросын Онцгой комисст гүйцэтгэх ажилд явуулсан билээ. Гэхдээ Свердлов бол хүн муу таньдаг, Төв Хорооны боловсон хүчний хэлтсийг өөрийнх нь тэмдэглэлийн дэвтэр оролдог гэж үздэг, бүр Туруханскийн цөллөгт байхдаа “хувиа хичээгч” гэж нүүрэн дээр нь улайм цайм хэлдэг байхад нь МАНЬ ХҮН гомддоггүй байсан юм. Свердлов бол бүхэлдээ эгэл сайн залуу, гэхдээ гарамгай хүн биш. Тэгээд ч Ленин түүнийг цэвэр ёслолын албан тушаалд буюу Бүх Оросын Төв Гүйцэтгэх Хорооны даргаар тавьсан юм. Свердловыг нас барсны дараа Ленин энэ албан тушаалд Тверийн тариачин нэг эр, “бүх оросын ахлагч” хэмээгдсэн Калининыг олж авсан.

Талийгаач Зержинский Ягодаг бас нэг их ойшоохгүй, хоёрдугаар зэргийн албанд хэрэг эрхлэх газрын даргаар байлгаад байсан юм. Гэхдээ Зержинский хэдийгээр олон сайн талтай ч гэсэн төрөлхийн тайж зантай хүн.

Бас тайж зантай, нэмэрт нь арван дөрвөн хэл мэддэг (большевик хүнд арван дөрвөн хэлний хэрэг юу байна вэ?) Менжинский Доод Новгородын ердийн эмийн санч Ягодагаас Зержинскийд өөриймсөг санагдах нь зүйн хэрэг. Түүнээс гадна нөхөр Зержинский олон сайн талынхаа хажуугаар жаахан өнгөн дээрээ даналзах дуртайг хэлэх хэрэгтэй... Чухам тэр учраас Тройцкийд дургүй байсан, цаадах нь даналзахын хувьд түүнийг хол хаясан хүн билээ.

Боловсрол багатай “бичиг хэргийн хүн” Төмөр Феликсийн сэтгэлд төдийлөн нийцэхгүй байсан нь зүйн хэрэг...

Гэвч Улс төрийн ерөнхий газарт ариухан бурхад хэрэггүй, бас гоё сайхан улс хэрэггүй, удирдлагын урлаг гэдэг бол хэрэгтэй хүнийг хэрэгцээтэй газар нь тавьж хамгийн гол нь дараа хэрэггүй болсон цагт нь түүнийг зайлуулж чаддагт байдаг юм. Ягода бол одоохондоо яг байвал зохих байрандаа байгаа хүн, өөрт нь ярьж байгаа юмны жинхэнэ утгыг сайн ойлгоно.

Ягода хаант засгийн нууц албанд ажиллаж байсан байх гэсэн хардлага ор үндэсгүй зүйл биш байж магадгүй. Гэвч тийм явдал маш нарийн орооцолдсон байдаг тул тэр хардлагыг чухамдаа шалгах арга байхгүй. Тойруу баталгаа бол ямагт найдвар муутай, хувьсгалын дараа хэдхэн цагийн дотор хааны нууц албаныхан бараг хамаг архиваа устгачихсан учир шууд баталгаа бараг байхгүй. Хуучин туршуул агсан олон хүний нэр бид олж авсан билүү? Нууц албаныхан ул мөрөө баллаж чаддаг, буруу замаар будаа тээлгэж дөнгөдөг байсан юм чинь бидний олж авсан зүйл төдийлөн сайн баталгаа болохгүй. Ер нь түүнээс гадна намын эрх ашгийн үүднээс өөрийгөө авч үлдэхийн тулд харгис цагдаагийн газрын түшмэдүүдтэй харилцаж, янз бүр болохоос өөр аргагүй явсан хүмүүст олон жилийн дараа эргэлзээтэй мэт санагдахаар нөхцөл байдал тохиолдож байсан байж болно.

Аль нэг хүн хааны нууц албаныхантай холбоотой байсан гэдгийг нотлоход хэцүү, гэхдээ тийм сэжиг төрж, тэр талаар өчүүхэн төдий ч гэсэн баримт байгаа бол холбоогүй байсан гэдгийг батлах нь бүр ч бэрх. Ягодатай холбоотой зарим нэг баримтыг нэг хүн гаргаж ирсэн, тэдгээр нь шууд хамаарах зүйлгүй, үнэмшил багатай байсан боловч хүсэх юм бол Ягодаг нууц тагнуул гэж буруутгахад хангалттай баримтууд байсан юм. Тэдгээр баримтыг гаргаж ирсэн хүнд ТЭРЭЭР нам үүнийг үнэмшил муутай зүйл гэж үзэж байна гэж тэр үед нь хэлээд энэ асуудлыг хэзээ ч, хаа ч дахин бүү ярь гэж тушаажээ. Тэгээд тэр баримтуудыг өөртөө үлдээсэн байна. Ягода үүнийг мэдэж байгаа ажээ. Баримт материалыг гаргаж ирсэн хүнийг ч үлдээж, түүнд бүү хүр гэсэн. Үүнийг ч Ягода мэдэж байгаа. Айхынхаа эрхэнд үхэр нохой мэт үнэнч байх болно, энэ бол итгэл үнэмшлээрээ үнэнч байснаас дээр, яагаад гэвэл итгэл үнэмшил бол өөрчлөгдөнө, харин айдас бол хэзээ ч арилахгүй.

Ягода уншсан зүйлээ ширээн дээр тавиад юу ч хэлсэнгүй. Сталин одоо зуур юм асуугаагүй учраас тэр. Бас Сталин руу эгцэлж харсангүй. Нөхөр Сталин руу харна гэдэг бол түүнд дуугүй асуулт тавьж юм ярихыг шаардлаа гэсэн үг. Тэрээр хэзээ, юу ярихаа өөрөө мэддэг учраас тэгж харахад дургүй билээ. Сталин түүнд өөрийнх нь бичсэн мэдээллийг үзүүлсэн нь гарцаагүй, гэхдээ энэ нь юу гэсэн үг болох нь одоо хэр тодорхойгүй байв.

Сталин Ягодагийн ойролцоо байсан сандал руу мэдэгдэм төдий дохив. Суу гэхийг бодоход урт яриа бололтой. Энэ ярианы дундаас цөөнгүй таавар таах хэрэгтэй учраас тун ярвигтай яриа болох нь гэдгийг Ягода дор нь ухаарчээ.

Сталин өрөөн дундуураа алхлах зуур ярьж эхлэв.

–Таны илтгэл юуг харуулж байна вэ? Нөхөр Запорожец оногдсон үүргээ биелүүлж чадахгүй байгааг харуулж байна. Ленинградд Зиновьевын эсрэг бүлгийнхнийг устгах нь хялбархан ажил байсан бол энэ үүргийг нөхөр Медведийн аппаратаар гүйцэтгүүлэхээр даалгаж болох

байсан. Гэтэл нөхөр Медведь бол Кировын хүн, харин нөхөр Киров бол Зиновьев намд болон түүнд өөрт нь ямархан хэмжээний аюул болж байгааг ухамсарлахгүй байна. Тоогүй хэрэг. Ленинградын байдлыг буруу үнэлж байна.

Сталин хивсэн дээгүүр чимээ гаргахгүй аажуухан алхална.

–Энэ байдлын онцлог юу вэ? Ленинградын байдлын онцлог нь зөвхөн тэндхийн намын байгууллагад зиновьевчууд олноороо үлдсэн явдал биш. Гол нь Ленинградын намын байгууллагын удирдлагад, нөхөр Кировын дэргэд тэднийхэн олноороо үлдсэн байна. Намын Арван дөрөвдүгээр их хурлын өмнө Зиновьевын төлөө саналаа өгч байсан түм түмэн хүн хаашаа алга болчихов? гэсэн асуулт гарч байна. Тэд нар тэндээ, Ленинграддаа байгаа, нөгөө л байрандаа, нөгөө л албан тушаал дээрээ байгаа. Нөхөр Киров тэд нар одоо намын жанжин шугамын төлөө, Төв Хорооны төлөө байгаа гэж нотолдог юм... Энэ тийм гэж үү? Тэд нөхөр Кировын төлөө байгаа нь үнэн, гэхдээ энэ бол тэд Төв Хорооны төлөө байгаа гэсэн үг биш! Нөхөр Киров тэднийг Ленинградад нь бүрэн бүтнээр нь хамгаалж үлдээсэн юм чинь тэд нөхөр Кировын төлөө байлгүй яах билээ? Тэд нөхөр Кировын төлөө байгаа нь зүйн хэрэг, тэд нөхөр Кировг үнэнч байгаа нь зүйн хэрэг. Гэхдээ нөхөр Киров өөрт нь үнэнч байгааг намд үнэнч байгаа мэт бодоогүй биз? Нөхөр Киров намыг өөртэйгөө адилтган үзэж байгаа юм биш биз? Арай эрт ингэж байгаа юм биш биз? Лениградын шударга коммунистууд Ленинградын намын байгууллагын иймэрхүү байдалд сэтгэл дундуур байгаад гайхмаар юм юу байна? Энд гайхмаар юм огт алга. Коммунистууд, ялангуяа таны наад мэдээлэлдээ зүйтэй бичиж байгаачлан Зиновьевын үеэс хойш өсөж бойжсон залуу коммунистууд тэгж сэтгэл дундуур байгаа нь зүй тогтолтой зүйл. Тэд ийм байдлыг эсэргүүцэж байна. Тэдний өсөж өндийх, ахин урагшлах замд Зиновьевын хуучин боловсон хүчнүүд хөндөлдөж зогсчихоод байгаа учраас тэгж эсэргүүцэж байгаа юм. Цаадуул нь мэдээжээр өөрснийхнийгөө дэвшүүлээд бусдынханд зам тавьж өгөхгүй байгаа, гэтэл тэдний хувьд бусдынх болчихоод байгаа хүмүүс бол үнэнч шударга, Төв Хорооны талыг жинхэнээсээ баримтлагчид юм.

Сталин чимээ гаргахгүй аажуухан алхалсан чигээрээ хэсэг дуугүй болсноо яриагаа дахин үргэлжлүүлэв.

–Нөхөр Запорожецийн зорилт юу байсан бэ? Түүний зорилт бол Лениградын байдлыг өөрчлөх, Ленинградын байгууллагаас зиновьевчуудад хандах харьцааг өөрчлөх, троцкист болон зиновьевын аюулын цар хэмжээг харуулах явдал байсан. Нөхөр Запорожец юу гээчийг хийв? Юу ч хийгээгүй. Үүнийг хийхэд Киров, Медведь хоёр түүнд саад болоод болохгүй байгаа мэт гомдол мэдүүлж байна. Жинхэнэ чекист хүнд бол иймэрхүү гомдол зохихгүй. Аппарат өөрийнх нь биш Медведийн захиргаанд байна гэж гомдол мэдүүлсэн гэж байгаа. Тэнэг толгой! Нэг бол өөртөө таарах аппарат сонгож бүрдүүлэх хэрэгтэй, эсвэл ажил амжуулах чадал байхгүй гэдгээ хүлээх хэрэгтэй.

Сталин гэнэтхэн Ягодагийн дэргэд зогтусав.

–Зиновьев, Каменевийн талынхныг бүрмөсөн цэглэх хэрэгтэй. Нөхөр Киров өөрийгөө зиновьевчуудаар хүрээлүүлчихээд байна, гэтэл цаадуул нь түүний энэ бүх ачийг нэг л хариулах вий. Нэг зүйл гарцаагүй гэсэнээ Сталин дахин өрөөн дундуураа алхалж, Киров Лениградад Зиновьевын талынхныг хадгалж байгаа учраас өнөөдрийн тодорхой нөхцөлд

түүнийг зайлуулах явдал тэднийхэнд ашиггүй гэдэг нь гарцаагүй. Гэхдээ засгийн төлөө тэмцлийн байдал нөхцөл хурцдах үед Киров тэдэнд хэрэггүй болно. Үүнээс гадна дайны аюул бий болох юм бол байдал бас хурцдаж болно. Гэтэл дайн бол гагцхүү Төв Хорооны эсрэг хүчинд л ашигтай, дайн засаг солигдох замыг нээдэг учиртай. Одоо Зиновьев, Каменев хоёр нөхөр Кировыг Төв Хорооны эсрэг гол цохих хүч болгон ашиглахыг оролдож байна, гэтэл мань хүн тэдэнд хэрэггүй болох цаг ирнэ, тэр үед тэд нар улс оронд хямралын байдал бий болгохын тулд түүнийг зайлуулна. Киров Сталины эсрэг троцкист могой өвөртөлж явна, гэтэл тэр нь нөхөр Кировыг өөрийг нь хатгачихгүй байгаа? гэв.

Тэрээр ширээн дээрээс Ягодагийн мэдээллийг авч түүн рүү хаяв.

–Намд ажил хэрэг л хэрэгтэй болохоос биш бичиг цаасны хэрэг байхгүй. Та явж болно.

Сталин Ягодаг гаргав. Мань хүн өөрийг нь ойлгов уу? Бүгдийг ойлгосон. Гэхдээ Киров Москвад шилжиж ирэхийг зөвшөөрвөл хамгийн зүйтэй болох юм. Тэр Төв Хорооны нарийн бичгийн дарга юм чинь, Төв Хорооныхоо нарийн бичгийн даргаар л ажиллаг л даа. Нүдэнд ил байх юм. Оржоникизетэй ойртчих нэг тал байна, гэхдээ Киров Төв Хорооны нарийн бичгийн даргын хувьд аж үйлдвэрийг бүхэлд нь, түүний дотор хүнд үйлдвэрийг хариуцах тул Серго аппараттайгаа хамт түүний харьяанд байж таарах учраас тэр хоёрын нөгөө наалинхай үерхэл юу болж хувирахыг харна аа, гайгүй. Оржоникизе ухаанаар гоц биш, тэр хосын хувьд адагт нь байгаа хүн, гэхдээ Кировт шууд захирагдахаас дургүйцэх болно. Тэгвэл тэгж л байг, цаанаа хорон юмгүй сэжиг бол хамтарч ажиллахад хамгийн сайн үндэс суурь мөн.

Сталин үүднийхээ өрөө рүү гарч өөр лүүгээ нөхөр Ежовыг дуудахыг Поскрёбышевт тушаав.

Ежов Төв Хорооны аппаратад хорин долоон онд орж иржээ. Бараг одой гэлтэй жижигхэн хүн. Сталин намхан нуруутай хүнд дуртай, өөрийнх нь чац 160 сантиметр.

Хэн түүний нэрийг санал болгосныг Сталин мартчихжээ. Энэ бол ховор тохиолдлын нэг. Мехлис билүү? Поскрёбышев юм уу? Товстуха юу? Тэд нарын л аль нэг нь. Үүнээс өмнө Ежов Казахстанд намын ажил хийж байсан юм.

Тэрээр нарийн бичгийн дарга нарын газар ажиллах зуур сайн хүн гэдгээ харуулжээ. Хэн, хэзээ, хаана, ямар ажил дээр байсныг андахгүй, хэдэн зуун хүний нэр усыг цээжээр мэднэ. Заяанаасаа боловсон хүчний ажилтан. 1930 онд МАНЬ ХҮН түүнийг Төв Хорооны боловсон хүчний хэлтсийн эрхлэгч болгожээ. Тэгээд ч алдсангүй. Ежов Төв Хорооны мэдлийн ямар ч ажилтан, түүний дотор Улс төрийн Товчооны аль ч гишүүний тухай арван минутын дотор бүрэн дүүрэн мэдээ өгнө. Энэ ахархан эр хүнийг нэр хүндээр нь онцгойлдоггүй, намын гишүүний хугацаа, нийгмийн гарал, урьд байгуулсан гавьяа энэ тэрийг падгүй гэж үздэг учраас бүх хүний нэр дээр данс нээжээ. Энэ мэт үзүүлэлт тухайн хүнийг онцгойлж үзэх ёстой мэт хуурамч эрх олгодог учраас Ежов эдгээр ойлголтыг хуучирсан зүйл, тэр ч байтугай хортой зүйлд тооцно. Түүний хувьд Улс төрийн Товчооны гишүүд Төв Хорооны мэдлийн бусад аль ч хүнээс юугаар ч ялгаагүй учраас мань хүн тэдний тухай материал танилцуулж байхдаа хөхөлбөр нүднийх нь харц гөлөрсөн янзтай болдог ажээ. Тэрээр нарийн бичгийн дарга нарын газар байгаа аливаа хувийн хэлхээ холбоогүй цорын ганц хүн бөгөөд алс холын Казахстаны урьд өмнө хэн ч эс мэдэх намын ажилтан учраас дээр үеийн элдэв холбоогоор

гагнагдсан ажилтан нарыг үзэн ядна. Чухам энэ учраас аппаратын хүмүүсийг сарниан бутаргах ТҮҮНИЙ бодлогыг хэрэгжүүлэн, боловсон хүчний “хэлхээн” дотроос хамгийн гол чухал гогцоог сугалан авч тэрхүү хэлхээг хайр найргүй эвдэлж байлаа. Ежов бол мэдээж ганцаархнаа хүн, тэр хүчирхэг “хэлхээтэй” тэмцэхдээ өөрийн биеийг, өөрийн байр суурийг хамгаалж байсан юм. Мухар сохроор үзэн ядна гэдэг бол зөв шийдвэр гаргахад саад болдог, улс төрийн бодлогод муу шинж чанар гэдэг нь гарцаагүй. Гэхдээ зан чанарын муу шинжийг ч гэсэн ашиглаж бас болно. Ежов бол “цагаан гартан” биш. Ежов бол “хар гартан”, ийм гар ч гэсэн ажилд хэрэг болдог. Дэмий хоосон яриад байхгүй шууд л хийнэ. Ёс суртахууны элдэв болзол, болно болохгүй гэх юмыг огт санаанд орохгүй. Гаднаа даруухан боловч нэр алдарт дуртай, хүмүүсийг удирдаж, тэдний хувь заяаг шийдэж байх санаатай. Гэхдээ өрөөн дотроо, ширээнийхээ ард, хавтаст хэрэг, нөгөө бүхнийг чадах данс даягаа харж байгаад нууцаар шийдэж байх санаатай. Тэрээр Дотоод явдлын ардын комиссарын газрын байгууллагуудыг чухамдаа хэдийн хяналтдаа оруулчихсан, тийм ч учраас Ягода түүнийг ад үзэж байгаа, ингэхлээр энэ чиглэлд тэнцвэр олдсон гэсэн үг. Арван долдугаар их хурал дээр МАНЬ ХҮН түүнийг Төв Хорооны бүрэлдэхүүнд оруулсан, энэ нь мань хүний хийж дөнгөсөн цөөхөн өөрчлөлтийн нэг. Одоо түүнийг Дотоод явдлын ардын комиссарын газрын байгууллагууд, шүүх, прокурорын газрыг хянуулж байхын тулд нарийн бичгийн дарга нарын газрын бүрэлдэхүүнд оруулах хэрэгтэй, тэгвээс тэнцвэр бүрмөсөн найдвартай болно. Бие биеэ үзэн яддаг Ежов, Ягода хоёрыг энд байж байхад энэ чиглэлээр санаа амар байж болно.

Сталин сандал руу дохив. Ежов суугаад тэмдэглэлийнхээ дэвтрийг өмнөө гаргаж тавив.

—Төв Хорооны бүтцийг жаахан өөрчлөх, Төв Хорооны аппаратыг шинэ хэлтсүүдээр өргөтгөх санал байна гэж Сталин хэлэв.

Нөхөр Сталин “Санал байна” гэж хэлсэн бол энэ санал нөхөр Сталинаас өөрөөс нь гарч байгаа гэсэн үг юм.

—Яагаад ийм санал тавих болов? хэмээн Сталин өөрөөсөө асууж байгаа мэт асуулт тавив.

Тэгээд өөрөө хариу хэлэв.

—Энэ санал бол ухаалаг бодлоос үүсэж байна гэж би бодож байна.

Ежов үзгээ зэхэж бариад тэмдэглэлийнхээ дэвтэр лүү харна.

—Бид тэгэхэд нөхөр Рязановын нэг хэргийг уучилсан, Пятаковоос болж тийм хэрэг хийсэн учраас л бид уучилсан юм. Харин чухам хэргийнх нь тухайд яривал жигшмээр хэрэг. Төвөөс очсон комиссыг баривчилна гэж байх уу! Ингэж дураараа загнах нэг ч мужийн намын хорооны нарийн бичгийн дарга байхгүй. Гэтэл үйлдвэрийн дарга тэгж загнасан байна, тэр ч байтугай хотын намын хорооны нарийн бичгийн даргатай ч зөвлөөгүй гэж байгаа. Энэ бол ноцтой дохио гэж өгүүлээд Сталин түр чимээгүй болов.

Ежов толгой өөд татахгүй бичиж байна.

—Энэ дохио юуг харуулж байна вэ? хэмээн Сталин дахин өөртөө асуулт тавив.

Тэгээд өөрөө хариуллаа.

–Энэ дохио бол аж үйлдвэрийн удирдах боловсон хүчнүүд хяналтгүй байгааг харуулж байна. Аж үйлдвэрийн аппарат зөвлөлтийн аппарат байснаа техник шүтэгчдийн аппарат болж хувирч байна. Энэ бол их аюултай зүйл!

Сталин ингэж хэлээд цаанаа нэг л учиртай чимээгүй болов. Энэ нь нийт олон түмэнд хүргэвэл зохих нэгтгэн дүгнэсэн үг хэлэх гэж буйн гэрч ажээ. Ежов энэ үгийг яг бичиж авахын тулд анхаарлаа төвлөрүүлэв.

–Техник шүтэгчдийн аппарат эдийн засгийн ноёрхол руу тэмүүлж байна, эдийн засгийн ноёрхол бол улс төрийн ноёрхол, энэ чинь марксизмын цагаан толгой шүү дээ. Бид техник шүтэгчдийг эдийн засгийн ноёрхолд, өөрөөр хэлбэл улс төрийн ноёрхолд хүргэж болохгүй, тэгэх юм бол пролетарийн диктатурын эцэс болно гэсэн үг.

Сталин Ежовыг бичиж дуустал хүлээгээд

–Нөхөр Оржоникизе энэ аюулыг дутуу үнэлж байгаа нь тоогүй хэрэг юм гэв.

Ежов бичихээ болив. Улс төрийн Товчооны гишүүдэд хамаарах аливаа зүйлийг тэрээр бичиж авахгүй, гагцхүү тогтоож авах ёстой.

–Гэвч нөхөр Оржоникизе аппаратынхаа өөртөө үнэнч байгааг нам, улсад үнэнч байгаа мэт үздэг манай дээд удирдлагын олон хүний алдааг давтаж байгаа хэрэг. Техник шүтэгчдийн аппарат нөхөр Оржоникизед үнэхээр үнэнч байгаа юм. Ер нь ч яагаад үнэнч байхгүй байх билээ? Нөхөр Оржоникизе энэ аппаратыг элдвээр өмөөрөн хамгаалж, намын хяналтаас гарган, түүний бие даах гэсэн хандлагыг өөгшүүлж байгаа, хорлон сүйтгэгч ямар ч инженерийг баривчлахыг эсэргүүцэж байгаа, түүгээр ч барахгүй Аж үйлдвэрийн намынхныг шүүн таслахыг эсэргүүцэж байсан. Ийм нөхцөл байдалд техник шүтэгчдийн аппарат түүнд үнэнч байх нь мэдээж. Гэхдээ зөвхөн нэг хэсэгтээ л үнэнч байх болно, хүчээ хурааж байгаа үедээ л үнэнч байна. Тэгээд хүчээ хурааж гүйцсэн цагт тэд нар нөхөр Оржоникизегүйгээр учраа олцгооно! Рязанов Пятаковын томилсон комиссыг баривчлаад буцааж хөөж явуулсан байна. Гэтэл Пятаков чинь нөхөр Оржоникизегийн орлогч шүү дээ! Тэгвэл Рязанов маргааш гэхэд нөхөр Оржоникизегийн өөрийнх нь томилсон комиссыг буцааж хөөхгүй гэсэн баталгаа хаа байна? Нөхөр Рязанов Москвагаас очсон комиссыг хөөснөөрөө улс төрийн хэрэг хийсэн байна. Улс төрийнхөө энэ алхмыг яагаад улс төрийн удирдлагын үүрэг гүйцэтгэж байгаа хотын намын хорооны нарийн бичгийн дарга нөхөр Ломиназетэй зөвлөсөнгүй вэ? Нөхөр Ломиназе нөхөр Рязановт хувьдаа нэр хүндгүй юм уу? Тийм гэж саная. Гэвч нөхөр Ломиназе ямар ч байлаа гэсэн эрхбиш намын байгууллагыг толгойлж байгаа хүн, тэгвэл намын байгууллагыг давж гарах эрх хэнд ч байхгүй...

Сталин Оржоникизегийн тухай ярьж байснаа болиод Рязановын тухай ярьж эхэлсэн газраас Ежов дахин тэмдэглэж эхлэв.

–Нөхөр Рязанов Москваг ч, орон нутгийн намын байгууллагыг ч, аль алиныг нь тоохоо бүр больж байна. Энэ юу гэсэн уг вэ? Энэ бол техник шүтэгчдийн аппарат өөрсдийгөө хяналт

байхгүй, шийтгэл байхгүй улс гэж үзэж байна гэсэн үг. Яагаад тэр вэ?

Сталин дахиад нэгтгэн дүгнэх бололтой түр чимээгүй болоход Ежов тэмдэглэлийнхээ дэвтэр лүү тонгойлоо. Сталин цааш нь ярив.

—Аж ахуйн аппарат түүнд дүйцэх дайны намын хяналт байхгүй учраас л хяналтгүй юм шиг загнаж байгаа юм. Ардын комиссарын газрыг Улс төрийн Товчооны гишүүн тэргүүлж байхад Хүнд аж үйлдвэрийн ардын комиссарын газрын намын үүр ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ? Ерөнхий газрын дарга нар, үйлдвэрийн захирлууд мужийн намын хороо, аягүй бол бүр Төв Хорооны гишүүн байхад ерөнхий газар, трест, үйлдвэрийн газруудын намын үүрийн нарийн бичгийн дарга нар их сайндаа л районы намын хорооны гишүүн төдий байгаа юм чинь энэ намын үүрүүд ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ? Тийм түвшинд намын байгууллагын үүрэг хэрэг дээрээ нойл юм. Рязановын хэрэг бидэнд эн тэргүүний зорилтыг шийдвэрлэх аргыг зааж өгч байна. Аж ахуйн аппаратын үйл ажиллагаанд түүнтэй дүйцэх дайны намын хяналт тавих хэрэгтэй. Намын аппарат улс орны бүх аппаратыг, түүний дотор улс ардын аж ахуйн аппарат, юуны түрүүнд хамгийн биеэ даасан, хамгийн боловсролтой, хамгийн ихэмсэг бардам боловсон хүчинтэй аж үйлдвэрийн аппаратыг хянаж байх ёстой.

Сталин “ихэмсэг бардам” гэдэг үгийг хэлэхдээ шар нүдэнд нь хорсол гялсхийж, тэгээд түр азнасны дараа, — Манай оронд техник шүтэгчдийг бий болгох гэсэн аливаа санаархлыг уг үндсээр нь устгаж, бут ниргэсэн байвал зохино. Тийм учраас одоо байж байгаа Төв Хорооны хэлтсүүд дээр аж үйлдвэрийн, хөдөө аж ахуйн, тээврийн гэсэн гурван хэлтэс нэмж бий болгох санал байна. Ингэх юм бол улс ардын аж ахуйн үндсэн салбарууд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр намын Төв Хороотой шууд холбоотой болно. Ийм замаар нам улс ардын аж ахуйн шийдвэрлэх хэсгүүдэд илүү туслалцаа үзүүлж чадах юм. Эдгээр шинэ хэлтсийн удирдлагууд нь ардын комиссарын зиндааны, эсвэл магадгүй түүнээс ч дээгүүр зиндааны ажилтан байх ёстой, тэгж гэмээж нь тэд нэр хүндтэй, жинтэй байх болно. Намын байгууллагуудыг өөрчлөн байгуулах талаар шийдвэрийн төсөл бэлтгээд надад үзүүлээрэй. Шинэ хэлтсүүдийн эрхлэгчийн албан тушаалд дэвшүүлэх хүмүүсийн нэрсийг сонгож олоод надад бас үзүүлээрэй. Хэлтэс бүрийг Төв Хорооны нарийн бичгийн дарга хариуцна, бас Улс төрийн Товчооны гишүүн ч хариуцаж магадгүй. Аж үйлдвэрийн хэлтсийг хамгийн чухал гэдгээр Улс төрийн Товчооны гишүүн хариуцах ёстой нь гарцаагүй. Жишээлбэл нөхөр Киров. Тэр чинь техникийн боловсролтой шиг санагдах юм. Дашрамд хэлхэд түүний бүрэн хувийн хэргийг надад авчирч өгөөрэй гэж нэмж ярив.

Сталин бослоо.

Ежов ч дэвтрээ хааж үзгээ энгэрийнхээ халаасанд хийгээд бушуухан өндийлөө. Сталин боссон хойноо,

—Рязановыг тэр үед шийтгэхэд Пятаковын өдөөн хатгасан явууллагыг зөвтгөсөн хэрэг болох байсан юм. Гэхдээ төвийн буруу байлаа ч гэсэн төвлөрөн удирдах ардчилсан зарчмыг зөрчиж болохгүй. Одоо энэ асуудлын учрыг мужийн намын хороо олбол таарна. Мужийн намын хороо тайлбар гаргуулж аваг, судалж учрыг нь олог, тэгээд үр дунг нь танд танилцуулаг. Тэр хэрэг цаасан дээр үлдсэн байх ёстой.

Сургуулийн төгсөлтөөс өмнө, бүр хавраар Малькова Шарокт утасдаж маргааш өглөө Шүүхийн ардын комиссарын газрын боловсон хучний хэлтэс дээр ир гэж мэдэгджээ.

Ийнхүү түүний асуудал шийдэгджээ. Үйлдвэрт очих болбол сайхан хэрэг, хэрвээ шүүх буюу прокурорын газар явуулах болбол гарцаагүй Москвадаа байна гэсэн үг, тиймгүй бол түүнийг Ардын комиссарын газар дуудахын хэрэг юу байна. Тэдний сургуулийнхан цөм аль хэдийн томилолтоо авчихсан, бүгд хөдөө хөөгдөөд байгаа билээ.

Юра маргааш нь товлосон цагт Малькова дээр ирэв. Хүүхэн түүнийг орж ирмэгц босоод,

–За явья! гэж товчхон хэнэггүй өгүүлжээ.

Тэгээд түүнийг энд тэндгүй бэх асгасан ногоон цаасаар бүтээсэн татуургагүй хуучин ширээ, гурван сандлаас өөр юу ч байхгүй, хана нь нүцгэн жижигхэн өрөөнд дагуулж ирэв. Тайзнаас бүрхүүлгүй чийдэн өлгөөтэй байх аж. Ямар зориулгатай нь мэдэгдэхгүй хаягдмал өрөө.

Ойрд угаагаагүй тоосондоо загалтсан цонхны дэргэд нэг намхавтар хүн зогсож байв. Тэрээр нөгөө хоёрыг орж ирэхэд эргэж харлаа. Малькова Шарокийг урдаа оруулснаа тэр даруй буцаж гараад хаалгаа хаачихав.

Нэг хэсэгтээ тэр хоёр бие биеэ сонжин харцгаалаа. Нөгөө хүн хүүхдэрхүү царайтай авч эвэр хүрээтэй том шил нь тун оворжуу болгожээ. Иймэрхүү хөшүүн янзын улс тамир муутай хэрнээ гоморхуу, өширхүү байдаг учраас Юра хэзээний тийм хүмүүсээс дөлдөг билээ. Сайхь хөшүүн өөрийгөө Дьяков хэмээгээд Юраг суу гэснээ өөрөө өөдөөс нь хараад суучихлаа.

–Нөхөр Шарок, та сургуулиа төгсгөж байна. Одоо ингээд хуваарилагдах ёстой, тэгэхлээр тантай тодорхой танилцах гэсэн юм. Өөрийнхөө тухай ярьж өгнө уу гэж Дьяков хэлэв.

Тухайн үедээ Малькова түүнийг яг ингэж хэлж угтаж байсан билээ. Боловсон хүчний хэлтсийнхнийг өөр өөрийн нүүр царайтай гэж хэлэмгүй юм байна. Тэгээд Шарок тэр үед яг Мальковад хэлж байсан шигээ хариулав. Оёдлын үйлдвэрийн ажилчны хүү, хуучин зорогчийн мэргэжилтэй, дээд сургуульд олон нийтийн тийм тийм ажил хийж байсан. Бас төвөгтэй зүйл бий, ах маань хулгайн хэргээр ял эдэлж байгаа. Товчоор хэлэхэд үйлдвэр лүү явуулаасай билээ хэмээж нэг талаас өөрийгөө юугаар ч муулахааргүй, нөгөө талаас шүүх, прокурорын байгууллагад ажилд тэнцэхээргүй харагдахаар хариулжээ.

Гэтэл Дьяков ахынх нь тухай хэдийн мэдсэн бололтой Малькова шиг элдвээр номчирхож сургаал айлдсангүй. Харин өөр нэг юмны тухай дэлгэрэнгүй шалгаав. Эцэг эх нь хаанаас гаралтай, юу хийдэг улс болох, хаана аж төрдөг, тэднийх ямар байртай, сургуулиа төгсөөд яах бодолтой байгаа зэргийг ширхэгчлэн асуув.

–Үйлдвэр лүүгээ буцаж очих хүсэлтэй.

Дьяков ойлгож байгаа бололтой толгой дохив.

–Би бол таны бодлыг тодруулах үүрэгтэй хүн, чухам яахыг дарга нар шийднэ. Би танруу утасдана аа.

Ингэхлээр түүнийг Ардын комиссарын газарт буюу прокурорт авах гэж байна, гагцхүү чухам ямар ажилд авах нь л тодорхойгүй байна. Бух төгсөгчдийн дотроос онцгойлж үзэж байгаа нь бахдалтай боловч өөрийнх нь төлөвлөгөөг нураах нь. Тэгээд Ардын комиссарын газар буюу прокурорын байгууллагад ажиллана гэдэг нь хэдийгээр Москвадаа байна гэсэн үг боловч мань хүн ямар ч атугай үйлдвэрт томилуулахаар хөөцөлдөхөөр шийдэв.

Дьяков хэд хоногийн дараа утасдаж Шүүхийн ардын комиссарын газарт хүрч ирэхийг хүсэв. Юра тийшээ очлоо. Дьяков түүнийг пропускийн товчоон дээр хүлээж байв. Тэр хоёр цахилгаан шатаар дөрвөн давхарт гарч түрүүчийн удаа Дьяковын түүнийг хүлээж авсан нөгөө өрөөнд орцгоолоо.

Цонхны хажууд комиссар цолтой нүсэр эр сонин уншаад сууж байв. Зах нь түдүүл улаан ягаан өнгөтэй байгаа нь Улс төрийн ерөнхий газрын цэргийн тэмдэг. Юра түүнийг ямар ажилд авах гэж байгааг ойлгомгоц бие нь арзасхийгээд явчихав.

–Нөхөр Березин гэж Дьяков мэдэгдэв. Березин сониноо тавихад Юра түүнийн цаатан янзын хүрэл царайг үзэж дахиад дотор нь хачин оргив.

Березин Юраг суу гэж гар дохив.

Дьяков зогссон чигээрээ байснаа бүр яриа эхэлсэн хойно Березин мөн түүн рүү харж сандал руу толгой дохиход сая суулаа.

Березин Юраг чимээгүй ажиглаж байснаа,

–Намын байгууллага таныг Дотоод явдлын ардын комиссарын газрын аль нэг байгууллагад ажиллуулахыг зөвлөмж болгосон юм. Би таны хувийн хэрэгтэй танилцсан. Ах чинь эрүүгийн гэмт хэргээр ял эдэлж байгаа юм байна хэмээн сунжруулан өгүүлээд, — Та түүнтэй хамт ял заагдсан хүмүүстэй танил байсан уу? гэж асуув.

–Би тэднийг шүүхийн хурал дээр л анх удаагаа харсан.

–Та ахтайгаа нөхөрлөдөг байсан уу?

–Ах надаас дөрөв ах. Би өөрийн гэсэн найз нартай, тэр ч бас өөрийн найзтай байсан.

–Та түүнтэй одоо харилцаатай юу?

–Эцэг, эхэд маань л захиа бичдэг юм... Тэд хариуг нь бичнэ... Хугацаагаа дуусгаад хөдөлмөрлөж шударга амьдрах замд ороорой гэсэн миний хүсэлтийг тэд нар уламжилдаг. Миний тэр зөвлөгөө тус болох эсэхийг бүү мэд.

Березинд ах нь пад байхгүй, өөрийг нь л сонирхож байна гэдгийг Юра тодорхой ойлгож байв. Тийм учраас үнэн санаанаасаа ярьж байна гэдэгт эргэлзэхээргүй хариулах хэрэгтэй, гэхдээ

бас энэ байгууллагад авахгүй байхаар хариу өгөх хэрэгтэй. Эд нар өөрснөө л түүнийг авахаа больчих ёстой. Березин нөгөө Будягин шиг гарамгай тэмцэгчдийн эгнээнд багтдаг учраас түүнд хэзээ ч итгэхгүй.

–Таны найз нар чинь хэн бэ? гэж Березин асуув.

–Гойд дотнын найз надад байхгүй хэмээн Шарок энэ бол гол асуулт гэдгийг ойлгож байгаа учраас болгоомжтой өгүүлэв. Березин чухам хэний тухай мэдэх гэж байгаа юм бол? Саша Панкратовын тухай юу, эсвэл Лена Будягины тухай юу?.. Гэвч Саша, Лена хоёр аль нь ч түүний нөхөд биш болсоор удаж байгаа билээ...— Надад гойд дотнын найз байхгүй хэмээн Шарок давган хэлээд,— Сурч байсан дунд, дээд сургууль бас манай байшингийн танилууд бий гэв.

–Та долдугаар сургуульд сурч байсан уу?

За, мэдлээ... Саша эсвэл Ленатай холбоотой зүйл байх нь.

–Тийм, долоод.

–Кривоарбатын хөндлөн гудамд уу?

–Тийм.

–Сайхан сургууль. Сургуулийнхаа нөхдөөс хэнтэй нь уулздаг вэ дээ?

Саша Панкратов дээр л хүрэх гээд байна. Хэлэхгүй байх уу? Тэгж яах ч юм билээ? Тэртэй тэргүй мэдэцгээж байгаа. Тэгээд ч өөрийг нь юу гэж буруутгах билээ? Тэр хоёрын хооронд ямар ч нөхөрлөл байгаагүй, харин дайсагнал л байсан. Гэхдээ тэр дайсагналын тухай ч бас ярихын хэрэггүй, баривчлагдсан хүнийг өөлж байна гэж санана. Үерхэл, дайсагналын аль нь ч байгаагүй. Нэг байшинд суудаг нас чацуу залуус, тийм учраас нэг сургуульд сурч байсан, дараа нь нэг үйлдвэрт ажиллаж байсан, энэ бүхэн аль эртний явдал...

Юра үг болгоноо нягтлан цэгнэж,

–Ийм юм л даа, бид нар яг нарийн яривал бие биетэйгээ уулзахаа больсон улс. Хуучин ч гэсэн санаандгүй л тааралддаг байсан юм, нэг байшинд байдаг болохоор. Одоо бол зүг зүгтээ тарж алга болцгоожээ. Жишээ нь Максим Костин явган цэргийн дунд сургууль төгсөөд Алс Дорнод руу яваад өгсөн, Александр Панкратов баривчлагдсан, үнэнийг хэлэхэд чухам ямар хэргээр баривчлагдсаныг би мэдэхгүй, Нина Иванова багш хийж байгаа, хааяа хашаан дотор тааралддаг юм, сайн байна уу, баяртай гэхээс цаашгүй... Өө тийм, бас Вадим Марасевич, манай байшинд биш, гэхдээ Арбатад байдаг юм, хааяа уулзалдана, тэр хэлний мэргэжилтэн... өөр хэн байдаг билээ? Лена Будягина Тавдугаар байшинд байдаг, бас л бараг тааралддаггүй юм гэв.

–Иван Григорьевичийн охин уу? гэж Березин асуув.

–Тийм.

–Таны сүйт бүсгүй, эмэгтэй найз бий юу?

Шарок Ленагийн нэрийг дурсангуут ийм асуулт тавьсан нь түүний тухай тэд нар сайн мэдэж байгааг харуулав. Тэд нар ч ингэж л мэдэж байх ёстой л доо. Тиймээс асуултын зорилго нь түүний амьдралын тухай мэдэх гэснээс урьдаар хэр зэрэг үнэнчийг нь шалгах явдал.

–Одоохондоо гэрлэх гээгүй байгаа гээд Юра инээмсэглэв.

–Театр, кинонд явах, бүжиглэх дуртай юу?..

Ленатай ресторанд явдаг байсныг мэддэг байх нь.

–Бүжиглэх дуртай.

–Аятайхан охидуудтай юу?

–Аятайхантай л бол зүгээр.

Березин хэсэг зуур чимээгүй болсноо,

–Та Панкратов гэж хэлсэн. Тэр чинь Александр Павлович Панкратов уу? гэж асуув.

–Тийм ээ, бид нар ч зүгээр л Саша гэдэг юм. Манай комсомолын үүрийн нарийн бичгийн дарга байсан. Гэтэл тэр баригдсан...

–Тэр ямаршуухан хүн бэ?

Шарок дахиад дал мөрөө хавчлаа.

–Түүнээс хойш их уджээ. Найман жил өнгөрчихсөн байна, тэгэхэд тэр шударга, сайн залуу шиг байсан, комсомолын удирдагч хэмээн Шарок инээмсэглэснээ, — Гэтэл дараа нь тэр чухам юу болсныг би мэдэхгүй гэв.

Үүнээс өөрөөр хариулж чадсангүй. Муугаар, тэр ч байтугай барагтайхан тодорхойлох юм бол баахан асуулт гарна, тэгвэл хариулах юм олдохгүй, тэгж ороогдож байхын хэрэг ч алга. Тэгэхэд Панкратов сайн хүү байсан, тэгэхэд Саша арван тавтай байсан, тэгэхэд Шарок ч бас арван тавтай байсан, тэгэхэд мань хүн бүх юмыг залуу итгэмтгий нүдээр харж байсан. Тэрээр одоо ч гэсэн итгэмхий нүдээр харж байна, тэгэхлээр ийм ил цагаан сэтгэлтэй, илэн далангүй бас тэгээд эрүүгийн ялтан ахтай хүн эд нарт хэрэггүй.

Саша Панкратовын тухай “чин санаанаасаа” аятайхан тодорхойлсон нь чухамдаа Шарокийн хувь заяаг шийдсэнийг мань хүн сэжиг ч аваагүй билээ. Березин Сашагийн тухай сайхан бодлоо энэ Шарок руу шилжүүлж, түүнийг Панкратов лугаа адил шударга сайн залуу байна гэж боджээ. Ингэж ноцтой алдсан, Березин энэ алдаанаасаа болж хожим ихээхэн хохирол хүлээсэн юм.

Харин энэ удаа бол ингэж хэлжээ.

–Бид таныг авах тухай эргэцүүлж бодно. Гэхдээ манайд ажиллах уу, үгүй юу? гэдгээ та өөрөө л юуны өмнө шийдэх ёстой. Онцгой комиссын байгууллага бол намын зэвсэгт отряд, энд ажиллана гэдэг бол чухал нэр төрийн хэрэг. Бид хэнийг ч хүчээр албадаж авдаггүй, та татгалзвал тэглээ гэж бидэнд гомдох юм байхгүй.

Тэрээр дахин Дьяков руу эргэж,

–Нөхөр Шарокт та утасныхаа дугаарыг өгчих гэв.

–Мэдлээ хэмээн Дьяков өндөсхийв.

–Асуудал шийдэгдээгүй байна, тэгэхлээр энэ яриа бидний хооронд л үлдэнэ шүү гэж Березин өгүүлэв.

–Би ойлгож байна аа гэж Шарок хариуллаа.

Заавал мань хүн байдаг нь юу вэ? Мань хүн бол онц сурлагатан биш, дундаж оюутан. Бас олон нийтийн ажилд ч дунд зэрэг, даалгасан үүргийг биелүүлэхээс цаашгүй. Яг ийм дунд зэргийнх нь л хэрэгтэй байдаг бололтой.

Тэрээр нөгөө хүнтэй өөрийнхөө тухай ярьсан зүйлийг эргэцүүлэх гэж оролдов. Березин эргэлзэх болно. Яагаад ах нь эрүүгийн хэрэгтэн байгаа юм бэ? Яагаад ресторануудаар хэсээд байдаг юм бэ? Тэр эрүүгийн хэрэгтэн ах нь бас элбэг тансаг амьдралд дуртай байж таараа, тэгээд л алт мөнгөний дэлгүүр тоносон хэрэг. Заавал ийм хүнийг бид яагаад авах ёстой билээ? Харин Дьяков бол Шарокийг дэмжинэ, өөрөө түүний нэрийг дэвшүүлсэн болохоор сонгож авсан хүнээ хамгаалах болно. Тэр хоёр бие биеэ харилцан ойлгосон ч юм уу, тэдний хооронд ямар нэг гүйдэл авалцах шиг болсон. Юра түүнтэй бол гар нийлэхдээ л нийлнэ.

Харин Березинтэй бол...

–Аавтайгаа морины уралдаан цуг үздэг үү? гэж Березин асуув.

–Үгүй ээ, үздэггүй.

Энэ асуулт Юрад хамгийн эвгүй асуулт шиг санагджээ. Эд нар өөрийнх нь тухай бүх юмыг мэдэж байна, эд нар бүх хүний бүх юмыг мэддэг улс байна. Гэтэл мань хүн Будягинаас л дандаа айдаг байсан билээ. Будягинаас биш Березинээс айх ёстой юм байна. Будягин нэрд гарсан, Березин нэрд гараагүй хүн, тэглээ ч гэсэн Березин бол гол хүч. Эд нар нууц эрх мэдэлтэй учраас ил эрх мэдэлтэй хүмүүсийн ард нь зогсож байгаа юм.

Дьяков хэдийгээр Березин өөрт нь юм хэлэх тоолонд овсхийн босдог ч гэсэн бас л хүчтэй. Юра түүнтэй анх удаа ярилцсанаа, Дьяков тэгэхэд яаж лаглайтал сууж байсныг нэхэн санав. Үгүй ээ, мань хүн ч тэдний сургуулиас муусайн дундчуудыг хайгаагүй л дээ, түүнд дундчуудын хэрэг юу байх билээ. Дьяков сонголтоо аль хэдийн яг хийчихсэн. Мань Шарок л ийм ажлын төлөө заяасан хүн, гэнэн хээгүй Максим Костин, хулчгар сэхээтэн Вадим Марасевич, хэтэрхий биеэ даасан Саша Панкратов энэ тэрийн хэн нь ч энэ ажилд таарахгүй.

Шарокийн гараас мултрах хүн гэж заяа нь байхгүй, түүний өмнө өөрийгөө зөвтгөж чадах хүн гарахгүй, мань хүн хэний ч үнэнчид ерөөсөө итгэдэггүй, энэ бүхэнд чин үнэнээсээ итгэхийн арга байхгүй, итгэдэг гэж зүтгэж байгаа хүн бол худлаа ярьж байгаа хэрэг.

Гүйцээ. Зүйтэй шийдвэр. Хувь заяандаа найдах хэрэгтэй. Өөрөө зөвшөөрч байгаагаа мэдэгдэнэ, тэгээд яадаг санж вэ дураараа болцгооно биз. Хүсвэл авна, эс хүсвэл авахгүй. Чухам тэнд л байвал мань хүн аюулгүй байх юм. Тэнд бол хэн ч түүнийг хөндөхгүй, тэд нар л бусад бүх хүнийг хөндөнө.

Юра Дьяковт утасдаж нөгөө асуудлыг нааштай шийдэж байгаагаа хэлэв.

—Орой ороод гараарай гэж Дьяков хариулав. Юра нэвтрэх бичиг барьсаар өрөөнүүдийн дугаарыг ажиглан урт хонгилоор алхлав. Өөрөө үнэхээр энд ажиллах юм гэж үү?

Дьяков түүнийг нэг бяцхан өрөөнд хүлээж авав. Умгар ч гэсэн өөрийнх нь өрөө учраас мань хүн эзэн хүн шиг додигор суух ажээ. Цэргийн хувцастай, цамцных нь захны түдүүлд гурван зураас байна. Хэдий хачирхмаар ч гэсэн цэргийн хувцас түүнд зохиж давжаа турьхан биеийг нь сүр оруулжээ.

—Чи зөв шийджээ.

Тэрээр мань хүнийг чи хэмээн өөрснийхөнтэйгөө ярьж байгаа юм шиг эелдэгхэн харьцах зуур ширээнийхээ нүднээс нэг хавгас гаргаж ирэв.

—Энэ чиний хавгас. Одоо ёсчлон бүрдүүлцгээе. Юра түүний сэтгэлд нийцэж байгааг мэдрэв.

—Хөөе Шарок, өнгөрсөн удаа чи Панкратовын нэрийг хэлж байсан, тэр ер нь ямаршуухан залуу вэ? гэж Дьяков өгүүлэв.

—Би ч түрүүн ярьсан шүү дээ... хэмээн Юра дал мөрөө хавчиж, — Сургуульд байхдаа комсомолын үүрийн нарийн бичгийн дарга байсан. Тэгэхэд бол шударга хүн гэмээр л сэтгэгдэл төрүүлдэг байсан юм. Хэрвээ дутагдал юу вэ? гэвэл бусдаас ухаантай, илүү мэддэг, их юм дуулсан хүн болохыг эрмэлздэг хүн гэж хэлмээр байна.

—Тэр чинь үнэхээр их юм дуулсан хүн байсан юм болов уу?

—Магадгүй гэж Юра санал нийлэв. Тэрээр бүхний учрыг ойлгож, одоо чухам юу ярихаа яг мэдээд авчээ. — Түүний нагац ах Рязанов том барилга байгууламжийн дарга. Ер нь манай сургуульд хариуцлагатай олон ажилтны хүүхэд суралцдаг байсан. Панкратов тэднийхээр орж гардаг байсан. Би бол түүнийг бусдыг манлайлж заах тушаах дуртай хүн л гэж хэлнэ.

—Тэр ч тийм бий, тэгээд л бөөн хэрэг тарьчихаж л дээ. Өөрөө ч юманд орооцолдож, үнэнч шударга сайн залуусыг ч бас орооцолдуулчихсан гэж Дьяков нухацтай өгүүлэв.

—Ямар ч гэнэ вэ нэг ханын сонин гаргасан гэцгээх юм.

—Тийм ч явдал бий, бас өөр шугамаар ч юмтай... Ингэхэд тэр чинь хариуцлагатай ажилтан

нарынхаас хэнийд очдог байсан юм бэ?

Будягиныг сонирхож байгаа хэрнээ дэндүү дээгүүр нэр гэж үзээд цохож нэрлэхгүй байна. Юра ч гэсэн бас түүнийг нэрлэхгүй, тийм мэдээлэл өөр хүнээс гарна биз. Березинтэй ярьж байхдаа мань хүн Ленагийн нэрийг хэлсэн, тэр нь хангалттай!

–Манайд Тавдугаар байшингийн хүүхдүүд суралцдаг байсан, тэднийхнээр л орж гардаг юм.

Дьяков Шарок руу хялайсхийн харав.

–Энэ анкетыг бөглөөд намтраа биччихнэ шүү... гэснээ хөгжилтэй гэгч, — Чи бид хоёрын ганзага нийлнэ гэж бодож байна хэмээн өгүүлэв.

Юра энэ байгууллагад эвгэйхэн таарч, шинэ нөхцөл байдалд дорхноо дасаж дадсан төдийгүй залуу нас, ялдам инээмсэглэл, задгай орос царайгаараа энэ газарт чимэг нэмжээ. Тэрээр нуруу гоолиг, хөдөлгөөн шалмаг нэмэрт нь юмны учир олохдоо сайн, ажил хэрэгч, төлөв тогтуун зантай, энэ бүх чанарыг нь Дьяков, Березин хоёр аль аль нь үнэлсэн билээ.

Березин Шарокийг ивээж байгаа нь албан тушаал түргэн ахих боломж олгож байвч мань хүн энэ ивээлээс болгоомжлохын хамт Дьяковоос эмээнэ. Березин бол түүнд хэдэн долоо хоногоор харагддаггүй, нүдэнд нь өртсөн цагт л мань хүнийг санадаг тэртээ дээр байгаа дарга. Дьяков бол дэргэд байгаа учраас Юрагийн туршлагагүй байдлыг дуртай цагтаа ашиглаж түүнийг нуга дарж чадна. Березин бол ганцаараа хүн, Дьяков шиг хүн зөндөө олон. Ер нь тэгж ярих юм бол Березиний шулуун зангаас Дьяковын элдэв ов мэх Юрагийн сэтгэлд илүү нийцтэй байлаа. Березин бол юманд итгэнэ, Юра бол юунд ч итгэхгүй, Дьяков бол итгэж байгаа дүр гаргана.

Гэхдээ Дьяковтой тун мэдээтэй байхгүй бол горьгүй, мань этгээд хутган үймүүлэгч гэдгийг Шарок дорхноо ухаарч, тун болгоомжтой байх болжээ. Дьяков өөрийнхөө ажиллаж байсан хэсэг хүнийг Юрад шилжүүлж өгсний дотор Вика Марасевич түүнд шилжиж иржээ.

Санаандгүй өгөв үү, эсвэл тэр хоёрын харилцааны тухай юухан хээхэн мэддэг байх нь уу?

Шарок юмыг яаж мэдэх вэ хэмээн,

–Би энэ Вика Марасевичийг чинь мэднэ, нэг сургуульд сурч байсан юм. Түүний ах бид хоёр нэг ангид сурдаг, тэр өөрөө нэг анги ах билүү, нэг анги дүү билүү байсан, одоо бүр мартчихжээ гэж хэлжээ.

Дьяков энэ тухай мэддэг эсэхээ өчүүхэн ч хар авахуулалгүй хэнэггүй царайлж,

–Энэ хатагтай гадаадынхантай явж байж баригдсан юм, чи хавгаст хэргийг нь харахлаар аяндаа мэднэ. Гэхдээ энэний эцэг профессор Марасевичийнд Глинский ирдэг юм, чухам тэр холбоонд л энэ хүүхнийг оруулж ашиглах ёстой юм. Чи түүнийг Маросейкийн гудамжин дахь байранд хүлээж авч байх болно. Түүний хуваарьт өдөр-мягмар. Арван нэгэн цагт. Яг цагтаа ирнэ, хожимдохгүй шүү гэжээ.

Үнэхээр Вика яг арван нэгэн цагт ирэв. Юра хаалга нээж өгөв. Вика Шарокийг үзэнгүүт зогтусан цахилгаан шатаа бараадахыг бодов. Тэрээр Юраг Дотоод явдлын ардын комиссарын газар ажилладаг гэж мэдэх боловч өөрийг нь мань хүн хөтлөх юм гэж даанч санаанд орсонгүй.

—Ор ор, хонгор минь, битгий бишүүрх, ойрд уулзсангүй шүү гэж Юра нүүр дүүрэн инээмсэглэв.

Цэх шулуун нуруутай, цэргийн хувцастай цэвэрхэн сайхан Юра хүүхнийг өрөөнд оруулж уриалгахан гэгч нь сандал тавьж өглөө. Түүний эдэлж хэрэглэж байгаа суран бүс, цэрэг цамцан дээрх дөрвөлжин тэмдэг, савхин гутал энэ тэр цөм цоо шинэхэн, гял цал оргиж байв. Тэрээр эрх мэдэл, хүч чадал, олз омгийн биелэл гэлтэй харагдах агаад хүүхний энэ биелүүлж байгаа үүрэгт ер бусын гойд юм огт байхгүй мэт түүнтэй нөхөрсөг төдийгүй бүр хөгжүүн ярилцлаа. Тэр хоёр ийм нөхцөл байдалд уулзаж байгаад бас ер бусын юм огт байхгүй юм шиг.

Харин Вика дараачийн уулзалтад бүсэлхийгээрээ бариухан бас хагалгаа ихтэй зуны даашинзтай ирж, сурмаг гэгч нь мөрөвчөө мултлан булбарай цагаан мөрөө нүцгэлэхэд Юра тэр мөр лүү нь тоомжиргүй хялайснаа, хүүхний нүд өөд эгцлэн харж,

—Чи бид хоёр нэг сургуульд суралцаж, завсарлагаанаар нууцгай үнсэлдэж байсан юм гэхэд тэр бол хэнд ч пад байхгүй. Чи бид хоёрын хооронд өөр ямар нэгэн юм болоогүй шүү. Ойлгов уу? гэжээ.

Хүүхэн мөрөвчөө дээш нь болгож,

—Тийм, тийм, тэгэлгүй яахав гэж ичингүйрэн гүвтнэв.

Ломиназегийн хэрэг явдлаас болж профессор Марасевичийн гэрт нэвтрэх шаардлага гарсан учир Дьяков тухайн үедээ Викаг энэ ажилд татан оруулсан байжээ. Ломиназегийн хамсаатан Глинский Марасевичтэй нэг нутаг ч юм уу, эсвэл садан төрөл ч юм уу, тэднийхээр орж гарч, тэнд гадаадынхантай уулзаад байсан байна. Тэгэхлээр тэд нараар дамжуулж гадаадын коммунист намын Ломиназегийн талыг баримтлагчидтай яагаад нууцаар холбоо барихгүй байх билээ?

Эхлээд бодоход санамсаргүй гэмээр ийм нэг санаа төрснөөр таамаглал үүсгэх, Черийн үнэмшил муутай мэдүүлэгт хүч оруулж, тэр мэдүүлгийг Коминтернд шууд холбоогүй хүмүүсийн нэрээр бататгах боломж гарчээ. Хөндлөнгийн холбоо аливаа хэргийг их сүр бараатай, итгэл үнэмшилтэй болгодгийг ч хэлэх үү. Баримт бол ямар ч байсан жинтэй, Викагийн өчүүхэн мэдүүлгийг нөгөө таамаглалтай холбон авч үзвээс ер өчүүхэндэхгүй, Глинскийн нэр Ломиназегийн элч нар гэж үзэх хэсэг хүний нэрэн дотор орчихож байгаа юм. Элч нар мөн гэдгийг Чер гарцаагүй нэхэн санана. Нөгөө талаас Глинскийн эхнэр дээд сургуулийн захирал, тэр сургуульд түүний орлогч захирал Криворучкогийн толгойлсон троцкист нууц бүлэг байсан.

Шарок Глинскийн хүү Яныг бүр дунд сургуульд байхын мэдэх бөгөөд эцэг нь Лениний тухай ярихыг нь сонссон, эх нь гэж ихэмсэг албархуу авгай байдгийг үзсэн билээ. Хожим тэр авгай

Саша Панкратовын сурч байсан дээд сургуулийн захирал болсон, тэгээд дашрамд өгүүлэхэд түүнийг сургуулиас хөөсөн хүн. Сашагийн хэрэг цагаа болохоор нөхрийнх нь хэргийн хэсэг болох төдийгүй хожим бүр өөрийнх нь хэрэгт холбоотой болно гэдгийг тэнэг толгойт тэр авгай мэдсэнгүй л дээ.

Одоо мань Шарок энэ хэргийн учрыг олох болж байна.

Энэ шинэ ертөнцөд хуучин танил нэрстэй учирсан нь өнгөрсөн өнөө хоёрыг холбож өглөө. Тэр өмнөх амьдралд нь доромжилж, ад үзэж байсан хүмүүсээс өшөөгөө авах бодит бололцоо байгааг Шарок анх удаагаа барим тавим мэдрэв. Саша Панкратов өөрөөс нь аваагүй ч гэсэн ямар ч атугай зохих хувиа хүртжээ. Бусад нь ч мөн хүртэх болно.

Юрагийн Викаг хүлээн авдаг байр Дьяковынх, харин Дьяков өөрөө Ревекка Самойловна гэдэг ой гутам царай дортой боловч улс төрийн эдийн засгийн ухаан заадаг багш учраас улс төрийн хувьд сайн боловсорсон, хазгар нуруутай бүдүүн эхнэрийндээ суудаг билээ. Дьяков Сталины “Ленинизмийн асуудлууд” гэдэг цорын ганцхан ном уншдагийг Шарок ажигласан, гэхдээ мань хүн авгайнхаа ачаар улс төрийн боловсролтой болжээ.

Шарок Ревеккад ер нүд дасахгүй байлаа. Үнэнийг хэлэх юм бол мань хүн еврейд ерөөсөө дургүй юм. Орон сууцны хороо, сургууль энэ тэр дээр еврейг еврей биш хүнээс хэн ч ялгаж чадахгүй, гэтэл Юра ялгадаг байжээ. Эцэг эх хоёр нь бас ялгана.

Шарокийнхны еврей нарыг ад үзэх үзэл бол өгөршиж архагшсан үзэл. Эцэг, өвөг эцэг энэ тэр нь Москварецкая гудамжнаа оёдолчны үйл хийж, зэргэлдээ Зарядьегийн хөндлөн гудамнуудад Глебовын хорооны хавьд еврей нар олноороо аж төрдөг, яг тэнд нь тэднийхний синагог[10] байдаг байсан үеэс л Шарокийнхны толгойд ямар нэгэн еврей эргэлдээд байх болжээ. Тэр оёдолчид, элдүүрчид, малгайчдыг дэлгүүрийн дээрэлхүү залуус шоглож дооглоцгооно. Гэтэл эрх мэдэлгүй байсан тэд нар одоо дарга нар болцгоочих нь тэр. Өөрийнх нь ах Иван бичиг үсэг ч үгүй хүн мөртлөө эрх дархтай болчихоод байгааг тэсвэрлэхийн аргагүй, гэтэл тэр нь нөгөө еврей Янкельтэй хамтран алба хааж байна гэхэд бүр байж суухын арга байхгүй. Хөгшин Шарок шинэ байгууллыг сөрсөн эсэргүүцлээ еврей нарыг үзэн ядах үзэл болгожээ. Жинхэнэ байгууллынх нь эсрэг тэмцэнэ гэхэд аюултай хэрэг.

Дьяков өөрөө царай зүс, бие бялдраар шалихгүй учраас Ревеккатай гэрлэжээ гэж Юра боддог байлаа. Тэрээр Дьяковт еврей нарын тухай юм яриагүй, ер нь мань хүн еврей нарын тухай юу ч эс ярина. Гэртээ иртэл эцэг нь энэ сэдвээр хэл амаа билүүдэж байхад мань хүн тамшаалахаас цааш дуугарахгүй.

Одоо мань хүний хувьд гэрийнхэн нь яггүй асуудал болж хувирлаа. Тэрээр ээждээ байрны гадаа дэмий чалчихыг хориглож амархан учрыг олжээ. Хаалттай бараа хуваарилах газар аль нэг юм байнга өгдөг учир ээж нь өдөр болгон тийшээ яваад ер нь ч гадаа дэмий сууж байх цаггүй болжээ. Эргэж ирэхдээ цүнхэнд нь юу байгааг хүн амьтанд мэдүүлэх хэрэг юу билээ хэмээн байрныхаа гадаа саатаж зогсохоо ч больсон аж. Харин эцгийн тухайд гэвэл асуудал төвөгтэй байв. Тэрээр одоо хүртэл гэрээрээ юм оёсоор байгаа. Нэг их биш, сард хоёр гуравхан костюм оёно, гэхдээ үүнийгээ санхүүгийн байцаагчаас нууж илүү орлогоороо морин тойруулгад очиж мөрийцнө. Энэ бүхэн Юрагийн нэрэнд хор хүргэж байгаа бөгөөд түүний дэвших замыг баллачихаж мэдэх билээ.

Өвгөн хувиараа үйл хийх нь түүний хувьд энэ түмэн хараал идсэн засгаас хамаарахгүй байгаагийн илрэл учраас цусаар уйлсан ч тэр ажлаа орхихгүй гээд болж өгсөнгүй. Өвгөн үйлдвэр дээрээ бол хэн ч биш, зүгээр л нэг ажилчин, харин эндээ бол эзэн. Мань хүнээр Москвагийн хамгийн ганган хүүхнүүд хувцас оёулах гэж чармайдаг боловч тэр болгон түүн дээр орж чадахгүй, нэг орж гэмээ нь үнэ хаялцахын сөхөө байхгүй, үгээр нь орж зулгуйдан аргадна. Мань өвгөн өөрөө ч гэсэн хөөрхөн хүүхнүүдээр нүд хужирлах дуртай, тэд нарын сиймхий оймстой цэвэрхэн хөл, худлаа долгинож байгаа ч гэсэн аальгүйтэх энэ тэр нь түүнд

аятайхан байдаг аж. Тэрээр залуухан, гоё хүүхнүүдээс захиалга авахыг урьтал болгоно, хөөрхөн бол заримдаа еврей хүүхэн байсан ч захиалгыг нь хийж өгнө, нүдээ ухаад өгчихмөөр тормолзсон хар амьтад байх л даа! Залуу зандан, чийрэг танхи хүүхнүүд байвал болох нь тэр, мань хүн бас хөх сэргэр, бие шүүслэг байхад дуртай, чавганц нараас тэр ч байтугай ахимагдуу авгай нараас бэлхүүс ч байхгүй, хувцасны сүр ч мэдэгдэхгүй хэмээн захиалга авдаггүй болой.

Юрагийн ганц хүндэлдэг, ганц сайн хүн нь эцэг нь. Тэрээр эцгийнхээ аж төрөхийн гүйлгээ хар ухааныг үнэлдэг билээ. Өөрөө эцгийнхээ хувьд цорын ганц дотно хүн нь гэдгээ бас мэднэ. Эцэг нь Володькаг хайр найргүй жанчдаг байсан хэрнээ Юрад хуруу ч хүрч үзээгүй. Эх нь гэж гудамжны хэрүүлч авгай, ах нь гэж эрүүгийн хэрэгтэн, ийм хоёр хүний эсрэг бие биетэйгээ төстэй, хоёулаа гоё, хоёулаа амьдралд дуртай аав хүү хоёр гэр дотроо сөрөн зогсож буй аж. Шарок өвгөн хүүгийнхээ шинэ байдлыг юу гэж үзэж байгаагаа аль нэг юмаар ямар нэг хар авахуулсангүй. Ер нь тухайн үедээ Юраг комсомолд элслээ, бас намд элслээ гэж буруушаагаа ч үгүй, сайшаагаа ч үгүй, Ленатай холбоотой боллоо, хожим түүнийгээ тасаллаа гэж бас буруушаагаа ч үгүй, сайшаагаа ч үгүй юмсанж. Энэ бол хайхрамжгүйдээ тэгсэн бус, итгэсэндээ тэгсэн хэрэг. Одоо бүх юм улсынх, бүгд л улсад алба хааж байна, дор хэндээ хаах билээ, харин яаж хаахын тухайд бол хүн болгон чадах чадахаараа хаана. Эцэг нь өөрөө бол улсаас ул хамаарах байдлаа хамгаалан үлдэж чадсан, гарынхаа ажлыг яасан ч орхихгүй. Энэ тухай дурсана гэдэг бол эцгийгээ хэзээ ч өршөөхөөргүй доромжилно гэсэн үг.

Салж нүүцгээх юм уу? Өөрийгөө, бас эцэг эхийгээ Москвад хүртэл ховорхон байдаг бүтэн орон сууцнаасаа салгах уу? Эцэгтэйгээ нэгмөсөн муудалцах уу?

Юра юу ч бодож олж чадсангүй. Гэхдээ амьдралынхаа төвөгтэй байдлыг ажлынхаа газраас бас нууж хориглосонгүй. Энэ тухай хөндлөнгийн хүнээс мэдсэнээс бүрмөсөн мэдэж аваг гэж боджээ.

Тэрээр,

–Манайх энэ байшинд бүр дайны өмнөөс аж төрж байгаа юм, айлууд нь цөм танил тал болцгоочихсон, тэгээд нэг нь пиджакныхаа өнгийг эргүүлүүлнэ, нөгөө пальтогоо тайруулна, гурав дахь нь нэг юм нөхүүлнэ.

Гэтэл манай эцэг оёдолчин хүн, хугас шил юм олж уухаасаа буцахгүй шүү, чи юу андах вэ дээ! хэмээн Дьяковг тайлбарлав.

–Эцэг чинь үйлдвэрт ажилладаг хүн, ажлын бус цагаар нэг хоёр нөхөөс тавих бол гэмт хэрэг биш, хугас шил юм уучих бол гэмт хэрэг бас биш гэж Дьяков хариулав.

Хүн амьтан юу гэж бодож, юу гэж ярьж болзошгүйг Дьяков үл тоомсорлоно. Шарок тэр хоёр энд хүний амьдрал, хүний хувь заяаг шийдвэрлэж байгаа улс, тэд нар дайсантай хийж байгаа тэмцлийн тэргүүн шугам дээр байгаа улс, тэд онцгой хариуцлагатай тийм учраас онцгой эрхтэй улс. Тэдний албан ажил төдийгүй хувийнх нь амьдрал хүртэл нууц зүйл. Тэдний амьдралыг хэтэрхий сониучирхаад байвал тийм хүнийг ямарч янзаар авч үзэж болно.

Юра одоо Дотоод явдлын ардын комиссарын газрын ажилтны дүрэмт хувцастай явдаг болжээ. Өглөө болох гэж байхад гэртээ ирнэ, үдийн хоолноос хойш ажил руугаа явна, байрныхаа гадаа бараг хүнтэй тааралдахгүй, тааралдаж гэмээ нь анзаараагүй дүр гаргана.

Байшингийнхан нь эцэгт нь захиалга өгөхөө больжээ. Захиалга өгдөг хүн урьд өмнө нь тийм ч олон байгаагүй, гэхдээ одоо өвгөн тэднийг бүр хавьтуулахгүй болжээ. Юра үүнийг эцэг нь өөрийнх нь байдлыг ойлгож аяг нь тааруулж байна гэж мэдэв. Эцэг нь тэр ч байтугай захиалга өгдөг гол хоёр хүүхнийхээрээ өөрөө очих болж, бусад захиалагч нар нь тэднийхээр ирдэг болов. Ингэснээр эцэг Шарок бүр баргийн хүнд олдохоо байж, тэгснээрээ улам ч алдартай болжээ.

Ийм байдлаар ахуйн энэ талын асуудал зохицож Шарокийнхны аль эртнээс элдвээр эргэлзэн тээнэгэлзэж, эмээн болгоомжилж байсан нь хулжин арилж, энэ айлын айх ичих юм багасан итгэл бэхэжлээ. Ахуйн өөр нэг талын асуудал буюу хүүхний асуудал хэвээр үлдэв.

Юра хүүхдийн тэтгэмж төлөхөөс айгаад хуучин ч гэсэн тун болгоомжтой явдаг байжээ. Шинэ ажлынх нь хүүхнүүд мань хүн рүү сээтэн хаядаг боловч өөрийн хамт олны дотроос хаяагаа хадрах ёс байхгүй. Шинэ холбоо үүсгэхгүй буйн гадна мань хүн хуучнаа сэргээхгүй байлаа.

Варька Ивановна түүнд сайхан санагдана. Хэзээний зүгээр охин, одоо бүр тэнгэрийн дагина л гэсэн үг! Гэхдээ шулмас. Нэг удаа байрныхаа гадаа тааралдаад нөхөрсгөөр инээмсэглэхэд өөдөөс нь ад үзсэн муухай харцаар харсан. Түүний эгч галзуу Нина, тэр хоёр бол Сашкагийн хамсаатнууд. Юра нөгөө нэг шинэ жил угтсаныг мартаагүй. Тэгэхэд Саша түүнийг доромжилсон, гэхдээ хамаг хэргийн эзэн бол Нина, тэр л хэрүүл шуугиан дэгдээсэн. Сашатай ярих юм байхгүй, Сашаг туугаад явчихсан. Бас эд нарыг ч хөөж явуулж мэднэ. Гэхдээ мань хүн энүүнд оролцохгүй, үгүй! Нэг хорооны улс. Дьяков бол ийм сэтгэлийг жижиг хөрөнгөтний хуурамч шударга журам гэж нэрлэх вий. Гэхдээ мань хүний орон гэр энд байгаа, ах нь ийшээ буцаж ирнэ, тэднийгээ дайснаар хүрээлүүлэхийг ер хүсэхгүй.

Шарок ганцхан хүүхнийг дурсахдаа л сэтгэл догдолно. Тэр нь Лена. Түүний хайрлаж зовсон царайг мартаж эс чадна. Эцгээсээ гадна үнэнч гэдэгч итгэж сайн байсан ганц хүн нь тэр, Лена түүний төлөө ямар ч хохирол хүлээхээс буцахгүй байсан, түүнийгээ бас нотолсон. Тэр нэгэн аймшигт шөнө, нөгөө эмнэлэг, тэгэхэд өөрийг нь илчлэх үг битгий хэл авиа хүний урманд дуугараагүй. Хайртай байсан хэрэг. Мань эр нөгөө сүүлчийн халуун гичний үнэрийг санасаар байгаа, одоо ч гэсэн тэр үнэр түүнийг гижигдэж байна. Тэр хүүхэн өөр хүнд дурлаж, өөр хүнтэй таарч, түүнтэй суух вий гэх бодол маажлан амар заяа эс үзүүлнэ. Мань хүн түүнийг золтой л алчихаагүй, бас хаясан, тэглээ ч гэсэн ганцхан өөрөө л түүнийг эзэмдэх эрхтэй. Ленаг эргүүлж авна, бүх юмыг албадаж мартуулна, дахиад эзэмдэн захирна.

Юра түүнтэй санаандгүй тааралдчих байх гэж тооцож байсан боловч тэр хоёрт тааралдахаар газар байсангүй. Тэрээр Ленагийн ажлын газрыг мэддэг боловч тийшээ очихоос аягүйрхэнэ. Тэгээд ийн нөхцөлд хуучин утасддаг байсан янзаараа гэр лүү нь утасдав. Утсыг Иван Григорьевич авсан тул харилцуурыг хаяхаас өөр аргагүй болов.

Маргааш нь ажлын газар луу нь утасдлаа.

Лена гайхаж хачирхсангүй, эсвэл гайхаж хачирхаагүй дүр үзүүлсэн байж ч магадгүй. Нөгөө ярьж цөхсөн хөндий дуу нь ор хэвээрээ. Бие үү? Сайн. Уулзах ий? Бололгүй яахав. Гэхдээ ажлаа тарангуут шууд зуслан руу яваад өгдөг. Утасдаж тохиролцох хэрэгтэй, бүгдээрээ цугларцгаадаг ч юм билүү?

Юра гайхаж орхив.

—Чи хэнийг хэлж байна вэ?

Бүсгүй инээд алдлаа.

—Нээрэн хэн ч байхгүй юм байна шүү дээ. Би Нинаг гэж бодсон юм, гэтэл тэр маань нэг семинарт яваад өгсөн. Вадим байж болох шүү дээ, чи түүнтэй утсаар ярь л даа.

Юра тийш нь утасдахгүй гэдгээ тэр даруй шийдсэн боловч,

—Тэгэхийг бодъё хэмээгээд, — Хоёулаа юу гэж тохирох вэ? гэв.

—Бүтэн сайнд л болж таарах байх.

Энэ хариулт нэг их баттай биш ч гэсэн ер нь иймэрхүү яриатай хүн л дээ. Үгийн төгсгөлийг тод хэлж, өргөлттэй газар нь түгдэрдэг учраас түүний хариулт дандаа тиймэрхүү эргэлзсэн янзтай байдаг юм.

Лена Театрын талбайгаас автобус хэдийд явдаг, шугамны (Серебряный борт гудамжийг шугам гэдэг ажээ) дугаар, зуслангийн байрны дугаар энэ тэрээ хэлж өгөөд автобус Москва руу буцдаг эцсийн буудлын тойрог дээрээс яаж явж очихыг тайлбарлав.

Буруушаах, гомдох, баярлах, хорсох, самгардахын аль нь ч байдаггүй шүү. Яльгүй ёсорхох маягаар доромжлох янз л мэдэгдсэн. Сурвалжит хүний дээгүүр зан. Гэвч мань эрийн хувьд бол энэ байдал болоод явчих нь тэр.

Иван Григорьевич, Ашхен Степановна хоёртой уулзахаас санаа зововч тэр хоёр юу ч мэдэхгүй байлгүй гэж бодогдоно. Иван Григорьевич түүнд дүргүй, яая гэх вэ дээ, хуучин ч ямар дуртай байсан биш. Гэтэл түүнтэй тааралдаа ч билүү, үгүй ч билүү? Ленатай усанд орохоор Москва гол руу яваад өгнө, тэднийд үдийн хоол идэхгүй, гагцхүү түүнтэй уулзаж, урьдынхаа харилцааг сэргээж бүх юмыг зохицуулж жин тан болгох л хэрэг байна. Бас Лена ганцаараа байж байхыг хэн байг гэх вэ.

Эцэг эх нь амралтаа аваад Владленийгээ дагуулаад нэг тийш яваад өгсөн байж болно шүү дээ. Тийм учраас ч өөрийг нь бүтэн сайнд ирэхийг урьж, хоёулхнаа байхаас айхдаа Вадимыг авчраач гэж гуйсан юм болов уу.

Хоёр хоногийн дараа бүтэн сайн өдөр Ленатай уулзана гэж бодохоос мань хүн өнгөрснөө дурсахад хүрэв. Тэрээр нэг удаа Ленаг өөрийнхөө өрөөнд хувцсаа сольж байх зуур Иван Григорьевичийн тасалгаанд яаж сууж байснаа нэхэн санав. Тэгэхэд түүнийг хүлээх хооронд зүрх нь догдлон шимширч байж билээ. Одоо зүрх нь тэр үеийнхээс бүр хүчтэй дахин догдолж

байх ажээ.

Шинэ ажил, шинэ зиндаа, нууц хүч чадал нь Шарокт биедээ эрэмших сэтгэл төрүүлнэ. Гэвч мань хүн Серебряный бор-т ирмэгц хулчийгаад явчихлаа. Гудамж буюу эндхийн хэлээр нөгөө шугамнууд нь гагцхүү дугаараараа ялгардаг ажээ. Тэгшхэн хайсан хашаанууд дээгүүр голт бор, малигын бургас сагсайна. Хашааны явган хаалга мөн хайс байх агаад тэндээс зуслангийн байр луу зассан явган зам мод бутны цаанаас зурайн цухуйна. Хашилт хаалт, харуул манаа, хөндлөнгийн хүн энэ тэр аль нь ч байхгүй, ёстой аглаг дархан газар гэлтэй.

Явган хаалга нь түгжээгүй байв. Юра хоёр талаар нь цэцэг тарьсан явган замаар явж цайвар ногоон өнгөөр будсан хоёр давхар зуслангийн байрны дэргэд ирэв. Хүн амьтан, анир чимээ огт алга. Жигүүрийн цэлгэр сэрүүвчинд өглөөний ундны дараа хараахан хурааж амжаагүй баахан аяга таваг овоорсон ширээ харагдана. Сав суулга олон, бас ширээ тойрсон олон сандал байхыг бодвол Лена ганцаараа биш бололтой.

Мань хүн ирснээ яаж мэдэгдэх учраа олохгүй сэрүүвчний гадаа тээнэгэлзэн зогсож. Тэгтэл үйлчлэгч авгай цонхоор шагайж эелдэгхэн хэрнээ гайхсан янзтай түүнийг харав.

–Би Ленатай уулзах гэсэн юм гэж Шарок хэлэв.

–Та тэгвэл тойроод яваад ир гээд сайхь авгай хаагуур тойрохыг зааж өгөв.

Юра байшинг тойрохдоо зэрлэг усан үзмийн мод ороож ургасан бүр жижигхэн бас нэг сэрүүвч байхыг олж үзэв. Тэндээс эрэгтэй хүний дуу сонсогдсонд Вадим гэдгийг тэр даруй танилаа.

Уул нь мань хүн түүнд утасдаагүй шүү дээ. Вадим яаж яваад энд хүрээд ирэв ээ? Ингэж давхардаж байгаа нь хачин юм. Салдаггүй гийчин юм уу? Хоёр нүүрээрээ уулзахгүйн тулд зориуд дуудагдсан хүн үү?

Гэвч эднийхэн бүрэн ам бүлээрээ гэртээ байгаа болохоор Вадим энд байгаа нь харин ч ашигтай юм боллоо. Түүний хоморгонд байхад маадгар байж болно, сургуулийн хуучин нөхөд байна л гэж харагдана шүү дээ. Лена энэ мангарыг өөрөө урьж, ашгүй хоёр биеэ гөлөлзөх зовлонгоос аварсан байна.

Тэрээр модон довжоогоор өгслөө. Лена, Вадим хоёр сүлжмэл сандал дээр сууцгааж байв. Дэргэд нь дугуй ширээнээс гадна нэг нарийхан сүлжмэл вандан байсан дээр Юра суулаа. Сэрүүвч нэг жижиг өрөөтэй залгаа ажээ.

Хэрэв Вика хамаг юмаа Вадимд чалчихсан бол тэр нь түүний харц, арга барагдан дургүйцсэн царай энэ тэрээр дорхноо мэдэгдэнэ. Гэтэл тийм сэжиг ор алга. Вадим бахь байдгаараа далан долоон үг дэлгэн бүгдийн анхаарлыг татчихсан, заан шиг лухгар дамай амьтан дороо товшлон аанай л өөрөө мэдэхээс биш өрөөлийн хүн мэдэхгүй элдэв юмаа ярьж байна.

Лена түүнийг чих тавин сонсож сууна. Тэрээр өчүүхэн ч хувирсангүй. Нөгөө л хуучин

янзаараа доогуур харсхийн ичингүйрэн инээмсэглэсээр. Нөгөө л ар шилэндээ туглан боосон хар үс, нөгөө л үл мэдэг дорвогор час улаан уруул. Элдэв зан гаргахгүй, байдгаараа л байж байна. Гэвч Юраг урьдын адил хайрласаар явааг мань хүн олж харав... Тэгвээс зүрх сэтгэл нь баяр бахархлаар бялхан булгиллаа.

Мань эр урьдын адил энэ эрхтэн дархтаны байшингаас аягүйцэж, аанай л аль нэг юмнаас эмээж байгаа боловч мань хүнээс өөрөөс нь хүмүүс айцгаах ёстой нь хачирхмаар санагдана. Тэгээд ч энэ сэхээтнүүдийн эрх мэдлийн нууц чухам юунд байгааг ерөөсөө ухаараагүй билээ. Чухам юуны учир мань хүн тэдний төлөө зүтгэх ёстой юм бэ? Ухаарч ойлгохгүй байна гэдэг л айж эмээнэ гэсэн үг юм даа.

Вадим манай төлөөлөгчид Венецид дөрвөн кино авч явсан тухай ярьж байв. Михаил Роммын “Булцаахай”, түүнд Галина Сергеева тоглосон, Александровын “Хөгжилтэй залуус”, гол дүрд нь Леонид Утёсов тоглосон, Посельскийн “Челюскин”, зургийг нь энэ онгоцон дээр явж байсан Трояновский авсан, Птушкогийн “Шинэ Гулливер” энэ дөрвөн кино гэнэ.

Вадим эдгээр киног шилж авахад биечлэн оролцсоноо битүүхэн ойлгуулж утга санаа үйл явдлыг нь ярьж, ялангуяа “Булцаахайг” их шуугиулна гэж цэцэрхэж байв. “Челюскинээс” бусад нь дэлгэцэнд гараагүй учраас Лена, Юра хоёр тэр кинонуудыг үзээгүй байх ёстой гэнэ. Ингэснээрээ Вадим дахиад л өөрөө мэдэхээс биш өрөөлийн хэн ч мэдэхгүй юм ярьж байгаа нь энэ.

Вадимын ярьж байгаагаар бол тун олон кино элдэв хэлбэрдсэн маяглал, дээдсийг дуурайх гэсэн оролдлогоосоо болж юу ч биш болж байгаа ажээ. Гэхдээ “Булцаахай”, “Хөгжилтэй залуус” хоёр ихээхэн найдлага төрүүлж байгаа. Манай кино үнэхээр ард түмний урлаг болох нь.

—Мопассаны “Булцаахай” ард түмнийх гэж үү? хэмээн Юра эргэлзэн асуув.

—Тэгэхгүй яах юм бэ гэж Вадим хашгичин, — Чи тэгээд л бодоод үзээч! Энэ чинь зөвхөн анхны явдал биш. Энэ бол милитаризмын эсрэг, фашизмын эсрэг чиглэсэн кино. Энэ бол ард түмэнд ойлгомжтой төдийгүй хэрэгтэй зүйл.

Юра хэлээ хазлаа. Мань хүний хувьд “Булцаахай” бол Мопассаны бусад аливаа зохиолын нэгэн адил давын өмнө хайр сэтгэлийн дуулал билээ. Гэтэл Булцаахайг пруссийн цэргийн дарга эзэмдэж авсныг Юра бодолцсонгүй л дээ.

—“Хуягт онгоц Потёмкин” бас л яггүй нарийн кино, гэхдээ хүмүүс үзээд л байсан даа гэж Лена өгүүлэв. Лена өөрийг нь аварч байгааг Юра ойлгов.

—Тийм шүү хэмээн Вадим санал нийлснээ, — Гэхдээ Эйзенштейний хэлбэрдэлт түүний хувьд яаж эргэлээ дээ? “Октябрь” нь үзэгчдэд ерөөсөө ойлгогдохгүй болсон, аугаа их сэдвийг ёстой нэг баллаж тавьсан. Лига Вертов гэдэг чинь энэ дээ! Тэр нөхрийн “Донбассын симфонийг” та нар үзээгүй юу? Холион бантан, бодит байдлын элэглэл! Одоо Вертов Лениний тухай кино хийж байгаа гээд Вадим тэвхгэр мөрөө хавчиж,

–Ийм нарийн юманд Зигаг оруулах гэж байх уу даа! Мундаг мастерууд, гэхдээ хэний талд байна вэ? гэдгээ нэг тийш болгох цаг болсон гэж дүрэмдэв.

Вадим тухайн үедээ Анри де Ренье болон бусад францчуудын тухай яаж бахархан бурж, тэр ч байтугай францын янхны нууц амрагуудын амьдралаас сэдсэн зугаатай элдэв ном өгч уншуулж байсныг нь хүртэл Юра санав.

Вадимтай үг сөрөх хэрэггүй байсан байж магадгүй. Гэвч “Булцаахайн” тухайд дийлдсэнийхээ өсийг авах хүсэл нь давамгайлав. Тэгээд,

–Вадик, чиний дүр өөрчлөгдөж байна шүү гэж хэллээ.

–Хонгор минь, сайжрах тийшээ л өөрчлөгдөж байгаа, сайжрах тийшээ шүү. Бид цөмөөрөө л хувирч байгаа, гол нь хаашаа явж байна гэдэгтээ л байгаа юм гэж Вадим шазруун өчив.

–Чи юу хэлэх гээд юу хэлж байна? хэмээн Шарок хөмсөг зангидлаа. Тэрээр Вадим ийм түрэмгий байгаад бүр гайхчихав. Энэ ч ямар Вика биш дээ. Хүч амтагдаж байгаа бололтой.

–Би сая хэлсэн юмаа л хэлэх гэсэн юм. Хүн хөгжих нь ёс, гэхдээ хаашаа хөгжиж байна гэдэг л чухал. Хүн болгон саад давна, гэхдээ ямар саад вэ, хаашаа давхиж явна вэ? гэдэг нь л чухал. Хаашаагаа? Дунд сургуульд байхад утга зохиолын тухай миний сонирхол туйлбаргүй байсан, гэхдээ юунд хүрсэн минь гол зүйл. Чи дунд сургуульд байхдаа комсомолд элсэх гэж яарахгүй байсан, гэтэл одоо намын гишүүн болсон байна, би бол ийм хувьслыг хэвийн хувьсал гэж үзнэ.

Ямар ч байлаа гэсэн хэрүүл маргааны байдал үүсгэж болохгүй, уудам сэтгэл гаргаж найр тавьж чаддаг байх хэрэгтэй, ингэлээ гэж Ленагийн нүдэнд зөв харагдахаас биш хохирох юм гэж огт байхгүй.

–Яриангүй тийм! Магадгүй, Эйзенштейн ч гэсэн социалист реализмын хүн болох юм болов уу? гэж Юра өгүүлэв.

Тэрээр нөгөө найруулагчийнх нь овог нэрийг буруу хэлчих вий гэж айхдаа зөвхөн Эйзенштейний нэрийг л дурсжээ. Хачин овогтой, хачин нэртэй улс. Дандаа л еврейчууд шүү, хэл хугалж мэдмээр юм.

Лена түүн рүү талархан харснаа,

–Вадимын яриад байгаа киноны зогсонги байдал дуутай кино бий болж байгаатай холбоотой юм болов уу? гэв.

Вадим тэр даруй эсэргүүцэж,

–Би зогсонги байдлын тухай ер яриагүй, харин дуутай киноны тухайд гэвэл би сүйд майд болохгүй байгаа. Ямар ч байлаа гэсэн кино бол аугаа их хэлгүй үзэгдэл. Дуу оруулчих юм бол кино дэлгэцэн дээрх театр болчихож мэднэ. Чарли Чаплин дэлгэцэн дээр ярьж байна гэж та нарын толгойд багтаж байна уу? Миний толгойд бол багтахгүй... гэв.

Лена Лондонд дуутай кино зөндөө үзсэн билээ. Дуутай кино тэнд хэвшчихсэн, манайд ч гэсэн хэвших л болно. Гэвч Вадимтай маргая гэсэнгүй, харин америкийн дуутай кино гарах үед үзэгчид америк жүжигчдийн хэлний дуудлагыг дооглон инээлдэж байсан нь санаанд орж мань хүүхэн дөнгөж инээмсэглээд дуугүй өнгөрөв.

–Тэгвэл нөгөө “Угтвар төлөвлөгөө”, “Алтан уул” энэ тэр яах болж байна? хэмээн Юра Вадимын өөрөөсөө илүүг зөвшөөрөх мэт эвлэрэнгүй асуув. Вадим инээмсэглэлээ.

–Эд нар чинь яриатай кино мөн гэж үү дээ? Зүгээр л Шостаковичийн хөгжмөөр дуу оруулчихсан кино. Тэр хөгжим өөрөө сайхан аятай, түүнээс гадна Шостакович ардын аялгууг үндэс болгодог учраас бүр ч сайхан байгаа юм. Энэ бол хөгжмийн зохиолч төлөвшихөд чухал зүйл.

Вадим юм мэддэгээ үзүүлж, ямар ч сэдвээр ярьсан амиа аргалах хүн гэдгээ Юрад итгүүлэхийг хүсэж байгаа аж. Юра үүнийг ойлгов. Өөрөөс нь айсандаа болоод ийм хүсэл ундарч байна гэдгийг ч бас ойлгов. Вадим хачирхмаар дайрч давшлаад буйн шалтгаан ч мөн тэр ажээ. Тэрээр инээдээ барьж чадалгүй Лена руу харж инээмсэглэсэнд цаадах нь тэвчээр гаргасанд нь талархан хариу инээмсэглэв.

–Усанд үдийн хоолны өмнө орох уу, дараа нь орох уу гэж? Лена асуув.

–Би та хоёрт хань болж чадахгүй нь хэмээн Вадим цагаа харж өгүүлээд, –Би Смидовичийнхээр нэг орох ёстой юм. Хэрэв чи зөвшөөрвөл үдийн хоолон дээр чинь эргээд ирье гэв.

Лена хувцсаа солихоор өрөө рүүгээ орж хаалгаа хаав. Вадим, Юра хоёр сэрүүвчин дотор үлдлээ. Ленагийн өрөө сэрүүвч рүү харсан нэг цонхтой, түүнд нь нимгэн хөшиг татаастай байв. Хөшиг салхинд хөөрөгдөн дэрвэхэд гараа дээш нь өргөөд даашинзаа толгой дээгүүрээ тайлж байгаа Ленаг харж болох байлаа. Юра цонх руу очиж биеэрээ халхлаад хөшгийг дарж зогсов.

–Вадик, ажил явдал ямар байна даа?

Вадим ширээн дээрх номуудыг янзалж байв.

–Цөм хуучин янзаараа. Чи ч утасдах ч үгүй, орж гарах ч үгүй болоо шив.

–Ажил их ээ.

Вадим ширээн дээрээс нэг ном авч Юрад үзүүлэв.

–Уншсан уу?

–Юу вэ?

–Панаевын дурдатгал.

–Санахгүй байна... Би эндүүрээгүй бол Панаевагийн дурдатгал гэж тааралдаж байсан.

–Тэр чинь энүүний гэргий. Албан ёсоор бол. Харин чухамдаа бол Некрасовын бүртгэлгүй авгай. Тэр хүүхний дурдатгал сонирхол татсаар л байгаа. Энэ бол Панаевын өөрийнх нь дурдатгал хэмээн Вадим номын хуудаснуудыг эргүүлж, — Энд сонирхолтой мөрүүд бий шүү гэв.

Зэргэлдээх байрнаас эрэгтэй хүний эвлэгхэн дуу гарлаа.

–“Саруулхан шөнө, чамд яагаад би дуртай билээ...”

Вадим номоосоо хөндийрч чих тавин чагнав.

–Чайковскийн ая, Яков Полонскийн үг.

Тэгээд дахин номоо эргүүлэв.

Лена нуруу, мөрөө ил гарган, нарийхан улаан сарафантай гарч ирлээ.

Өсгөлөн биетэй, тансаг сайхан хүүхэн. Яг Шарокт хэрэгтэй юм энэ.

Лена нүцгэлсэндээ ичингүйрэн инээмсэглэж,

–Би тэнд очоод хувцсаа солихгүйн тулд усанд орох хувцсаа шууд өмсчихлөө. Явцгаах уу? гэв.

–Одоохон, жаахан хүлээгээрэй! гэснээ Вадим хайж байсан зүйлээ сая олж,

–Нөгөө сонин юм чинь энэ. Панаев Белинскийгээс иш татсан байна. Белинский ингэж хэлжээ: “Хүний ёсны төлөөнөө биднийг хайр найргүй захирдаг шинэ суут харгис хүн, Их Пётр л бидэнд хэрэгтэй байна. Бид аллага хядлагыг дайран гарах ёстой. Бид хүний төсийг олохын тулд үүний урьд манайд Их Пётрын ташуур хэрэг болсон, одоо хүн гэдэг эрхэм нандин үгийн бүрэн утганд дүйх хүн төрхийг олохын тулд бид аллага хядлагыг дайран гарах ёстой. Бидний славянчуудын ухамсрыг сэхээрүүлэх ч амар даваа биш шүү. Манайхан хүн хэлэхээс нааш санадаггүй гэдэг тун үнэн үг шүү, эрхмүүд ээ, сайн муу юу гэж ярих нь хамаагүй, цаазын гэгээн илд гэдэг ч сайхан эд шүү” гэж уншаад номоо тавилаа.

–Ямар вэ?... Аан?

Юра энэ битүү хэрнээ улайм цайм егөөдөлд яаж хариулахаа эс мэдэн дуугүй зогсов. Биширмээр үгс байна, энэ Вадикаас юухан хээхэн сурч болох хүн шүү, гэхдээ ингэж улайм цайм...

Лена л дахиад мань хүний аминд орлоо.

–Би наад хэсгийг чинь уншсан. Энэ бол Белинскийнх биш, Панаевын бичсэн зүйл. Тэр л өөрөө энэ зүйлийг Белинскийнх болгочихоод байгаа юм.

–Үгүй, Панаев яг Белинскийгээс иш татаж байгаа юм хэмээн Вадим зөрж,

–Белинскийн энэ үг түүний тухай бусад дурдатгалд ч байдаг юм, тухайлбал Кавелиныхад бий. Нээрэн, Белинский аугаа их хүн байж дээ, тэгээд л Орост хатуу гартай удирдлага хэрэгтэй гэдгийг ойлгож байсан байна. Гэхдээ мань хүн тэр л эрин үеийнхээ хүн байсан болохоор нөгөө хатуу гар нь пролетарийн диктатур байх ёстой байсныг мэдсэнгүй, мэдэхийн ч аргагүй юм гэв.

Вадим улс төрийн ийм овжин буйд Юра дотроо бүр гайхаж хоцров.

–“Намуухан шөнө, чамд яагаад би дуртай билээ...”

Зэргэлдээх байрнаас нөгөө хүний дуу дахин сонсдож буй нь энэ.

–Сайхан дуулж байна, энэ хэн бэ? гэж Юра асуув.

–Манай айлын хүн, Төв Хорооны ажилтан, Николай Иванович Ежов гэж Лена хариулав.

Вадим энэ нэрийг анх сонсож буйгаа илэрхийлэн толгойгоо гэдэсхийлгэв. Уул нь мань эрд мэдэхгүй нэр гэж байх биш.

–Хэн болохыг нь мэдэхгүй юм, ямар ч атугай сайхан дуулж байна гэж Юра өгүүлэв.

–Сайхан эелдэг хүн байдаг юм гэж Лена хэллээ.

Лена Юратай хоёулхнаа үлдмэгц,

–Би Вадимын учрыг ер олохгүй байна. Үнэнээ хэлэхэд түүнээс айх шиг ч болох юм. Жигтэйхэн муйхар, баргийн юмыг тэвчиж өнгөрөөхгүй, хардаж сэрдсэн амьтан болчихож. Зөвлөлт засгийг өмөөрнө гэж! Хэнээс тэр вэ? Чи бид хоёроос юм уу? гэж өгүүлэв.

Лена өөрийнхөө онцгой байдлыг хэзээнээсээ нуух дуртай, тэрээр одоо ч гэсэн ялгарахгүйг хичээсээр бүлгээ. Тэглээ ч гэсэн мань хүн бол Вадим, түүний эцэг хоёр шиг улсын төлөө зүгээр зүтгэж байгаа төдийгүй улсыг удирдаж байгаа хүмүүсийн бүлэгт хамаарна. Юра ажилчин анги, ард түмний төлөөлөгч, одоо удирдлагууд чухам эдний дундаас төрж буй учраас бас улсыг удирдаж байгаа хүмүүсийн бүлэгт хамаарна. Чухамхүү үүний учир түүнийг тусгай албаны ажилд авсан хэрэг. Грановскийн гудамжин дахь Ленагийн байшин, мөн энэ Серебряный бор энэ тэрд нэртэй чекистүүд сууцгаадаг, сайхан улсууд ч бий. Ленагийн эцэг хүртэл нэг үе Бүх Оросын Онцгой комисс Улс төрийн ерөнхий газрын коллегийн гишүүн байсан. Вадим байж байгаа царайнаасаа нэг л хиймэл хуурамч байдалтай, сав л хийвэл “БИД чадна”, “БИД чадахгүй”, “МАНАЙД хэдийн бий болсон”, “МАНАЙ улс”... гэх мэтийн юм ярьж дургүй хүргэнэ. Нина Иванова эсвэл дор хаяхад Саша Панкратов энэ тэр л ингэж ярьж байж болох улс, энэ чинь тэдний ертөнц, тэдэнд ингэж ярих эрх бий. Харин Вадимд бол тийм эрх байхгүй. Мань хүн бол алба хаахаас өөр чадах юм байхгүй.

Лена Сашагийн тухай ийнхүү бодсон хоромд Юра бас түүний тухай ярьж, ингэж яг таарснаас Лена пал хийгээд явчихав.

–Вадим Сашаг баригдсан өдрөөс хойш шал өөр болчихсон юм. Би тэр дор нь үүнийг анзаарсан. Сашаг баригдсанаас болж мань хүн ухаан алдатлаа айсан. Одоо тэгж айснаасаа болоод хүн болгоноос чанга хашгирах гэж оролдож байгаа юм гэж Юра хэлэв.

–Нээрэн, Сашаг баригдсанаас хойш бид нар өөр хүн болцгоожээ хэмээн Лена гунигтайхан өгүүлэв.

Сашагийн тухай юу хэлэхээс их юм хамаарна гэдгийг Юра нөгөө Березинтэй ярьж байхдаа ойлгож байсан шигээ одоо ч гэсэн ойлгож байв.

–Сашаг өрөвдөх юм. Тэгэхэд миний буруу байжээ. Нөгөө Шинэ жил угтахад тэр намайг доромжилсон, би тэгээд бодитой хандаж чадсангүй.

–Ер нь юу болсон юм бэ? хэмээн Лена Юра руу итгэл горьдсон нүдээр харав.

Юра үгээ цэгнэн байж,

–Саша юмны манлайд явж сурчихсан хүн. Гэтэл тэдний сургуульд өөр хүмүүс манлайлах үүрэгтэй байж л дээ. Тэгээд Саша тэднийг унагаах гэсэн хүмүүстэй нийлжээ. Гэтэл тэр нь нугалааныхан намын удирдлагыг унагаах гэсэн хэрэг юм байж. Саша ингээд хоморгонд нь орчихгүй юу. Гурван жилийн хугацаатай цөллөг авсан, үүнээс бага ял болгуулах ямар ч арга байгаагүй, бусад нь бүгд олон жил шоронд суух, хориход албадан хийх ял авцгаасан гэв.

Түүний энэ үгнээс өөрөө ч гэсэн Сашагийн төлөө юмхан хийсэн мэт санаа цухалзав.

–Би дээд сургуулиа төгсөөд хуваарь авч Дотоод явдлын ардын комиссарын газар ажилд орсон, чи мэдэлгүй яах вэ дээ, би хуульч юм чинь хэмээн Шарок яриагаа үргэлжлүүлж, — Намайг яг ажилд орох үед Сашагийн хэрэг яригдаж байсан юм. Ний нуугүй хэлэхэд би тэр газар очин очтолоо чухам яах гэж дуудагдаж байгаагаа мэдэхгүй байсан шүү гэв.

–Өө тийм үү? хэмээн Лена гайхахын цаагуур гайхаад, — Гэхдээ та хоёр чинь өөр өөр дээд сургуульд суралцаж байсан, харин дунд сургуульд бол... Дунд сургуульд цөмөөрөө нөхөрлөдөг байсан шүү дээ гэв.

Юра тун учиртай инээмсэглэв.

–Леночка! Сашагийн найз нарыг нэг бүрчлэн шалгаж танилцаагүй гэдэг чинь ерөөсөө хэнийг нь ч шалгаагүй гэсэн үг биш. Саша бид хоёр нэг байшинд, нэг орцонд аж төрдөг байсан, нэг үйлдвэрт хоёр жил цуг ажилласан гэдгийг чи мартаж болохгүй. Вадик ухаан алдатлаа айсан нь санаандгүй хэрэг биш. Сашаг баривчлагдсаны дараа би чамаас эхлээд ямар ч хүнтэй уулзахгүй байхаас өөр аргагүй болсон, би юу гэж Иван Григорьевичид төвөг удах вэ дээ, мань хүн Сашагийн талаар хөөцөлдөж учир явдлыг нь нарийн мэдэхгүй хэрэгт хөндлөнгөөс оролцсон. Аз болоход учир нь нэгд нэгэнгүй тайлагдсан. Саша харьцангуй хөнгөн ялтай салж, түүний нөхдийг элдвээр сэжиглэхээ больсон, гэтэл Вадик л бухимдсан чигээрээ байх юм.

Лена толгойгоо яльгүй гилжийсхийн түүнтэй зэрэгцэн алхав. Тэрээр Юрагийн үгийг

үнэмшиж байна уу? Үнэмшихгүй байх шалтаг түүнд байсангүй. Тэрээр тусгай албанд хичнээн сайхан хүмүүс ажилладгийг мэддэг төдийгүй, энэ албаныхан ямар сайхан хүмүүсийг мөрдөж мөшгөдгийг бас мэднэ. Бусад найз нарыг нь дуудаж байцаагаад өөрийг нь үлдээсэн байж болно гэж бодовч ийм бодол сугалаа шиг онилгүй зүйл. Юрагийн хэлж байгаагаар бол бас өөрт нь зовлон байсан хэрнээ эцэгт нь элдэв төвөг удахыг хүсээгүй гэнэ. Тэр ч зүйтэй, Сталин аавд нь дургүй болохоор ялимгүй шалтагнаас болж томоохон мундраан болж мэднэ. Юрагийн оронд өөр хүн байсан бол тэгэхгүй байсан байлгүй. Яриад тайлбарлаад өгчих байсан байх. Гэтэл Юра яг энэ байгаагаараа л байдаг хүн. Ямар сэтгэлдээ хөтлөгдсөн нь гол зүйл.

Голын хөвөөн дээр хүн цөөхөн байв. Усны захад хүүхдүүд шуугилдан ус бужигнуулж дотуур богино өмдтэй сайхан шарагдсан хэдэн залуу элсэн дээр хөзөрдөцгөөх ажээ.

Лена сарафанаа тайлж биед нь наачихсан мэт усанд орох хар өмсгөлтэйгөө үлдэв. Тэгээд Юра руу дахин ичингүйрэн инээмсэглэн харсан боловч түүнийг богино өмднийхөө дотуур шуудгаа хийж өмсөж байхад хараа буруулсангүй.

–Цаашхнаа явцгаая, тэнд гүнзгий байдаг юм гэж Лена хэлэв.

Тэрээр махийлгасан гараараа ус ээлжлэн самрах тоолондоо толгойгоо бараг усанд хүргэн нааш цааш харж сэлэв. Юра ингэж сэлэхийг мэдэхгүй юмсанж. Өөрөө хоёр гараа чигээр нь ээлжлэн сэлнэ. Тэрээр Ленаг сайхан сэлж байхыг хараад гайхаж орхив. Тэр хүүхэн өнөөдөр мань хүний хуучин мэдэхгүй цоо шинэ чанараа харуулж байна. Учир зүйгээ эцэслэн олоход тийм ч амар хялбар биш байх вий гэсэн эргэлзээ төрж эхлэв.

Дараа нь нүцгэн ууцаа наранд ээж элсэн дээр хэвтэцгээлээ. Хүүхэн гараа зөрүүлж дэрлээд түүний хажуу талаас харж байхыг үзвэл хайрын сэтгэл нь нөгөө л хуучин янзаараа байгаа мэт Юрад бодогдоно.

Бүсгүй үнэхээр түүнд хайртай ажээ. Магадгүй, энэ хайр сэтгэлийг нь солих өөр дурлал ирээгүй болохоор тэгсэн байж ч мэднэ. Түүнээс гадна уяхан соргог сэрэлтэйг ч хэлэх үү, мань Юра түүний энэ насандаа үзсэн анхны бөгөөд цорын ганц эр хүнийг ч хэлэх үү. Юрагийн түүнд тарьсан зовлон тэрхүү сэрлийг нь улам бадраажээ. Бас Юра өөрөө ч гэсэн зовсон шүү дээ.

–Хоёул хэзээ уулзах вэ? гэж Юра асуув. Цаадах нь олон таван үггүй,

–Хэзээ л бол хэзээ гэж хариулав.

Тэрээр хүүхнийг гэртээ, өөрийнхөө өрөөнд дахиад аваачья гэвэл чадах билээ. Эцэг нь үрчийн ярвайна, эх нь хий л гараа алдална, тэр яах вэ, тэд тэвчих л болно. Гэтэл эр хүний нэг муу хашир зан саад болоод байв. Харьцаа сэргээхийн тухайд бол сэргээнэ. Гэхдээ жолоогоо бүр суллаж тавихгүй. Хоёр дахь удаагаа түүнээс тийм амархан салахад бэрх.

Тэгэхлээр хаа уулзах вэ? Хааш нь түүнийг урьдаг юм билээ? Цорын ганц байр байгаа, тэр нь Дьяковынх. Дьяков чухамдаа авгай дээрээ Замоскворечье суудаг хүн. Гэвч энэ бол болзоонд

нэг их тохиромжтой газар биш. Хэрвээ Лена мэдчих юм бол... Гэхдээ тэр юу ч анзаарахгүй өнгөрнө. Ор дэвсгэр гэж хуучин балиар юм байгаа, тэр ч байтугай цагаан даавуу байгаа эсэхийг ч мань хүн сайн мэдэхгүй. Зүгээр. Цагаан даавууг гэрээсээ цүнхэнд хийгээд аваад ирж болно.

–Тэгэхлээр байдал ийм байна. Манайх одоо засвартай, цөмөөрөө нэг дор унтаж, юмаа нааш нь цааш нь зөөгөөд нэг өрөөнөөс нөгөө рүү нүүж тохь тав муутай байгаа. Сургуульд цуг сурч байсан нэг нөхөр маань одоо амралтанд явчихсан, тэдний өрөөний түлхүүр надад бий. Тэнд хоёулаа жаахан сууж болох байна гэж Юра хэлэв.

–Болох байна хэмээн Лена зөвшөөрөв.

Варяг Лёвочкатай “Метропольд” бүжиглэснийг дуулаад Зоя бөөн баяр болов. Түүний овгийг Синявский гэдэг юм, зохион бүтээгч шугам зурагчин хийдэг ёстой сайн залуу, хүний ажилд дандаа тусална. Яаж хувцасладаг гээч! Дээд зэргийн оёдолчноор л хийлгэнэ. Үгүй, бас ямар сайхан бүжиглэнэ гээч! Нөгөө алдарт Ваган Христофоровичоос огт дутахгүй. Лёвочкатай сууж байсан тэр хөөрхөн бүдүүн хүүхэн чинь бас шугам зурагчин. Нэрийг нь Рина гэдэг юм.

Зоя Варягийн нүд рүү зулгуйдсан янзтай харна. Тэрээр Лёвочкагийн нөхөдтэй нийлэх юмсан гэж хэзээний мөрөөддөг боловч хараахан чадаагүй яваа ажээ. Сайхан төрнө гэдэг ч санаа амар юм даа, бүх юм хар аяндаа бүтэх юм.

–Ээх, чи ч азтай хүн юм аа хэмээн Зоя үнэн санаанаасаа санаа алдав.

Варяд бол Лёвочка доожоо муутайхан санагдаж нүдэнд нь төдий л буугаагүй. Гэхдээ ёстой сайхан бүжиглэж байсан, түүнээс гадна хамгийн гол нь өөртэй нь нэг анзааны залуу, ер нь тэдний бүлгийнхэн цөм өөрсдийнхөн. Эд нар бол Вика, Виталик хоёроос бас нөгөө гадаадынханд наалдсан хүүхнүүдээс тэс өөр улс. Варягийн сэтгэлд аятайхан санагдсан цорын ганц хүн бол Игорь Владимирович. Гэтэл тэр нь гучин тавтай байсан учир Варя түүнээс санаа зовоод байсан. Түүнтэй худлаа самбаганаж болохгүй, гэтэл үнэнээсээ явья гэхлээр мань бүсгүй тийм хөгшин хүнд сэтгэлээ өгч чадахгүй болохоор түүний толгойг эргүүлэхийг хүсээгүй. Харваас нүдэнд дулаахан буянтай хүнийг гомдооно гэдэг бол ичгүүртэй хэрэг. Варя шударга журмыг өөрийн гэсэн хэмжүүртэй, болох болохгүй юмыг бас мэдэх билээ.

Тэрээр Лёвочка өөрийг нь бүлэгтээ оруулах байх гэж горьдон урихыг нь хүлээж байв. Гэтэл нэг хэсэг чимээгүй байснаа “Метропольд” танилцсанаас хойш даруй хоёр долоо хоносны дараа нөгөө хүссэн урилганы сураг гарчээ.

Сэтгэл хөөрсөн Зоя бөөн баяртай гүйн ирж нөгөөдүүл чинь маргааш “Эрмитаж” цэцэрлэгт очих нь. Чи бид хоёрыг бас ирээрэй гэсэн хэмээх нь тэр.

Тэгтэл яг дараахан нь Вика утасдаж маргааш орой Игорь Владимировичтай “Канатик” ресторанд очицгооё гэж санал болгов.

–Би чадахгүй, маргааш “Эрмитаж” руу очно гэж Варя хариулжээ.

–Чи чинь хэнтэй тийшээ очих нь вэ?

–Лёвочкагийн нөхдүүдтэй. Би тэдний тэнд ажилд орж байгаа.

–Тэглээ гэж заавал тэд нартай явах ёстой юм уу? Утасдаад явахгүй гээд хэлчих. Игорь Владимировичид бидэнтэй хамт байна гэж би чамд хэлж байна шүү дээ.

–Үгүй ээ, болохгүй. Би очно гэчихсэн, тэднийг хуурч чадахгүй.

–Үгүй, би ч гэсэн бас амласан, гэхдээ нэг муу Лёвочка шиг баасанд биш Игорь Владимировичич амласан юм. Би өөрийгөө бодсон юм биш ээ. Чи түүнд, аятайхан санагдсан байна билээ. Тэр чинь авгайгүй хүн гэж Вика дургүйцэв.

–Уучлаарай, дараа бол болно шүү. Утасдаарай. Баяртай гэж Варя хариулав.

Тэгээд харилцуураа тавилаа.

Лёвочкагийн нөхдүүд одоо энэ “Эрмитаж” цэцэрлэгч гэсэн нөгөө “Метропольд” байдагтайгаа адилхан нэг олширч, нэг цөөрөн, янз янзын хүмүүс нэг явж, нэг ирж байв. Энэ ч зүйн хэрэг. Заавал бөөнөөрөө зугаалж ёстой биш. Тэд нарт ч зугаалаад байсан юм алга л даа, зүгээр л өөрснөө бусдыг харж, бусдад өөрснийгөө харуулах гэж гол хаалганы тэнд араалдан зогсоцгооно,

Эрэгтэйчүүд нь Лёвочкагаас гадна зураг төслийн газрын Том Воля, Бага Воля гэдэг хоёр банди, Ика гэдэг хачин нэртэй гоё залуу, бас Коминтерний хариуцлагатай ажилтны хүү Вилли Лонг гэдэг дүрсгүй царайтай бахим эр, алдартай бүжгийн багш Ваган Христофоровичийн туслах Мирон гэдэг олзны овсгоотой цагаан сэтгэлтэй бужгар хар хүү энэ тэр байв. Цорын ганц тогтмол бүжиглэдэг охин нь нөгөө пандгар Рина гэж сэвхтэй бүсгүй, наранд шарагдсан мэт битүү сэвхтэй тул тэр нь тун хөөрхөн харагдана. Том Воля үүнийг нарны үнсэлт гэнэ. Рина хөгжиж баясахын тулд нартад төрсөн гэлтэй. Нүүрэнд нь баясал бялхан сэвх нь бадарч хонгор шар үс нь алтан лицэх цэцэг лүгээ адил халиурч сагсалзан байна.

Бусад охид нь тэдэнтэй санамсаргүй нийлцгээжээ. Варя ч гэсэн өнөөдөр санамсаргүй нийлсэн хүний нэг. Гэвч түүнийг цоо шинэ зочин гэж үзэх хүн байсангүй. Ер нь эдний дотор тэр нь энэнийгээ эргүүлж байгаа гэх оноосон юм байхгүй, цөм адилхан охид, хөвгүүд бөгөөд Зоя шиг л жирийн шугам зурагчид ажээ. Энэ багачууд Варяг “Москва” зочид буудлын зураг төслийг хийж байгаа Щусевын уран барилгын зураг төслийн газар ажилд ороход нь тусална. Тэндхийн цалин хүнд аж үйлдвэрийн газрын зураг төсөл зохиодог байгууллагынхаас дутуугүй юм байж.

Хувилгаан бандийн дүртэй Лёвочка орсгор шүдээ ил гарган ялдамхан инээмсэглэнэ. Рина нар лугаа адил мишээн байна. Тэд шуугилдан хөхрөлдөн хажуугаар өнгөрөх охидыг ажиглан, элдэв муу юм бодолгүй тэдний тухай хэлэлцэнэ. Тэглээ гээд цаадуул нь ч эс уурлана.

Чухам энэ мөнгөгүй багачууд л энэ цэцэрлэгийн эзэд бөгөөд ийшээ ирэхдээ ч орох тасалбар аваагүй, тэгээд өнөөдөр аль нэг ресторанд бүжиглэхээр явцгаана. Олзны овсгоот цайлган сэтгэлт буржгар Мирон байн байн нэг тийшээ явж, Костя хэмээх хүний нэр оруулан нэг бүдэг бадаг юм ярьж байвч тэглээ гэж санаа зовж байгаа хүн байхгүй, ямар ч байсан ресторанд явцгаана гэдгээ мэдэцгээж байгаа бололтой.

Варя эд нарын дунд биеэ барихгүй санаа амар буйн зэрэгцээ үг цөөтэй Ика, Лёвочка хоёрт аятайхан санагдаж байгаагаа анзаарсан боловч өөрийг нь тэгэх тусмаа Зоя тэр хоёрыг хамтад нь ресторанд дагуулж явах эсэхэд эргэлзэж байв. Зоя тэдэнд сайн дураараа саймшран ангалзаж, дуу шуу нь хадаж байгаа тул цаадуул нь түүнээс салахын түүс болцгооно. Иймэрхүү

байдалд ер нь тэгдэг шүү дээ.

Орох хаалганы тэрүүхэнд нэг жижгэвтэр ширээ байх бөгөөд ард нь эрүүндээ сахалтай нэг хүн суух ажээ. Ширээн дээр хэсэг дугтуй, харандаанаас гадна “Гарын үсэг судлагч Д. М. Зуев-Инсаров. Бичгээр нь хүний араншинг судална. Үнэ тавин копейк” гэсэн пайз байна.

–Би аль хэзээний л араншингаа мэдэх юмсан гэж боддог юм, өөр тийм хүсэлтэй хүн байна уу? гэж Зоя гэнэт хэллээ.

Рина гайхшран нүдээ бүлтийлгэв. Вилли Лонг аргаа барсан янзтай санаа алдан гараа алдлаад,

–Даанч эргэлдүүр алга, байсан сан бол эргэлдэж тоглоцгоох юмсан гэж өгүүлэв.

Найз нь ямар алдаа хийснийг Варя ойлгов. Нөхдийнхөө өмнө араншингаа таалгана гэдэг бол саваагүй тоглоом төдий зүйл ажээ.

Зоя нөгөө ширээ рүү очоод Варяг,

–Варя, нааш ир! гэж дуудав.

Тэрээр Зоя руу очихгүй бол ресторанд явах горьдлоготой болно, хэрвээ түүн рүү очих юм бол хоёулаа хамтдаа хаягдах хэрэг гарна.

Гэвч мань хүн гарын үсэг судлагчийн ширээ рүү очлоо. Тэгээд санал сэтгэгдлийн дэвтрийг нь сөхөж үзэв... Максим Горький, Луначарский, нэрд гарсан жүжигчид... «Зуев-Инсаров танаа зад илчлүүлсэн Яро-ноос...»

Зоя дугтуйн дээр хаяг тавьж судлагчид өгөөд Варя руу дохиж,

–Бич! гэв.

–Яршиг, би бичмээргүй байна хэмээн Варя татгалзав. Мань хүн трамвайнд суух наймхан копейктой байжээ. Ер нь тэгээд хүний араншинг хүн тодорхойлж яаж чадах вэ дээ, тэгэх тусмаа дугтуйн дээр бичсэн бичгээр шүү, энэ бол ёстой дампуу ажил!

Гэтэл Зоя судлагчид хэдийн нэг рубль өгч харагдав.

–Энэ бид хоёрынх.

Варя дугтуйн дээр хаяг бичлээ. Тэр хоёрыг нөгөөдүүл дээрээ буцаж очиход хэн нь ч анзаарсангүй. Хүн нэг тийшээ явна, нэг газраас ирнэ гэдэг бол ердийн зүйл учраас тэр.

Мирон үзэгдэж нэг ойлгомжгүй юм хэлснээ дахиад алга болчихов.

Зояг нөгөө хоёр Волягийн нэгтэй юм ярьж байх зуур Рина Варяд,

–«Савой» руу очигдоо, гэхдээ Зояг авч явахгүй шүү гэж аяархан хэлэв.

–Түүнийг би хааш нь хийх вэ?

Рина чамайг авна, цаадхыг чинь бол авахгүй, яаж салахаа өөрөө мэдэхгүй юу гэх шиг дал мөрөө хавчив. Тэгээд юу ч хэлээгүй мэт нар шиг мишээсээр хараа бурууллаа.

Тэгээд нөгөөдүүл тарцгааж эхэллээ. Гэхдээ бөөнөөрөө биш, илбэдсэн мэт үзэгдэж харагдахын аргагүй сэмхэн сэмхэн ганц нэгээрээ гарч одоцгоов... Илбэдэхэд л за нүдээ нээгээрэй гэхэд хэн ч байдаггүй шүү дээ, яг л тэр гэсэн үг.

Зоя, Варя хоёр хоёулхнаа үлдчихсэн байв.

–Зугтацгаачихлаа хэмээн Зоя шивэгнэснээ уйлчихав.

–Чи машинаар хүргэж өгнө гэж горьдоо юу? Эсвэл зөөлөн дугуйтай морин тэргээр үү? гэж Варя дооглон асуув.

–Тэд нар гахайнууд, гол гахай нь Рина, тэр муу сэвхтэй маяг. Шаргачин гэж Зоя зүхэв.

Тэр хоёр олон амьтны дунд орж цэцэрлэг дундуур алхав. Цфасманы жааз хөгжим тоглож байсан задгай тайз, театр хоёрт завсарлага зэрэг эхэлсэн тул хөл ихтэй байв. Мань хоёр арга барагдан тэр хавьдаа хэд тойрсны эцэст өнөө оройжингоо холхисон нөгөө газар нь Ика зогсож байхыг үзэв.

–Охидууд аа хэмээн Ика хашгирч,

–Би та хоёрыг хайгаад байна шүү дээ. Бушуухан явцгаая! гэв.

–Хаашаа? гэж Варя асуув.

–“Савой” руу. Та нарыг зогсоол дээр хүлээгээд байдаггүй, цөмөөрөө яваад өгсөн, намайг та хоёрыг ол гэсэн юм.

–Бидэнд хэн ч юу ч хэлээгүй шүү дээ гэж Зоя зөрлөө.

–Мэдэхгүй л дээ, та хоёр дутуу ойлгоо биз. Түргэн явцгаая! гээд Ика илүү олон юм ярьсангүй.

Нөгөө хэд нь аль хэдийн том зууван ширээ тойрон сууцгаасан байв. Варя, Зоя хоёрыг ирлээ гэж хэн ч сүйд болсонгүй, ирээ л биз, суугаа л биз гэсэн царайтай, Ика тэр хоёрын хойноос өөрөө ирсэн юм уу, эсвэл цаадуулынхаа даалгавраар ирсэн юм уу гэдгийг Варя ер ойлгосонгүй.

Тэд нар бухар нөхөр нь хардаад амийг нь хороочихсон Алевтина гэгч нэг хүүхний тухай ярьцгаана. Рина шүүхийн хурал дээр байсан юмсанж.

–Тэр хүнийг өмгөөлөгч Брауде л аварсан. Ярих гэж ёстой урсгаж өгсөн, нөгөө шүүгч нар нь амаа ангайгаад мэлэрчихсэн сууцгааж байсан... “Национальд” орох хүрдэн хаалга манай охидыг рестораны шалиг амьдралд татан оруулж байна” гэснээ Рина хүрдэн хаалга яаж охидыг рестораны шалиг амьдралд татан оруулж байгааг дүрслэн гараа эргэлдүүлэв.

–Эмэгтэй хүн алчихсан байдаг. Гэтэл дөнгөж хоёрхон жил заана гэнэ ээ! хэмээн Зоя бухимдав.

–Соёлын хувьд хоцрогдсон гэдгээр хоёр жил нь ердөө л тэнсэн байлгүй.

Лёвочка орсгор шүдээ гарган хувилгаан хүү шиг инээмсэглэн байв.

–Хэрэв гол үүдээр хүрдэн хаалгаар орохгүй, өөр газраар орвол тийм амьдралд татагдахгүй хэрэг үү?

–Энэ дэлхий дээр хаа ч гэсэн хүмүүс ресторан, зоогийн газар цагаа өнгөрөөдөг шүү дээ гэж Вилли Лонг өгүүлэв.

Бага Воля гараараа нүүрээ таглаад мөргөл үйлдэж байгаа лалын сүсэгтэн шиг ганхан,

–Хөөрхий Алевтина, золгүй Алевтина, тэр зэрлэг бухар яалаа гэж түүнийг хутгалаа вэ, яалаа гэж өчүүхэн дэгдээхэй шиг хөнөөгөө вэ! хэмээн бувтнав.

–“Шарсан дэгдээхэй, жигнэсэн дэгдээхэй, бас аж төрөхийн хүсэлтэй дэгдээхэй...” хэмээн Том Воля дуу аялав.

–Хэрвээ хүрдэн хаалгыг авч оронд нь зүгээр ердийн хаалга хийчихвэл шалиг зам байхгүй болчих уу? гэж Лёвочка дахин асуув.

Мирон ирж ширээ рүү суунгаа,

–Нэг тоглолт дуусгаж байна, одоо ирнэ гэж хэлэв.

–Айсуй! гэж үүд рүү харж суусан Вилли өгүүлэв. Тэдний ширээ рүү гялалзсан хар шаахайтай, гоё костюмаа хайнгадуухан угласан хорин найм эргэм насны ханхар цээжтэй бяцхан сахалтай бахимхан эр ирж явав. Тэрээр танил хүмүүсээ мэндчилэхэд хариуд нь толгой дохин инээмсэглэсээр болгоомжтой хөнгөн алхаагаар танхим дундуур шуудхан явж харагдана. Энэ

бол Мироны “Эрмитажид” нэрийг нь цухалзуулж байсан Костя хэмээх цуутай бильярдчин ажээ.

Нөгөө хэд түүнийг тосгуулан мэндэлцгээв. Цаадах нь ширээний ард байгаа хүмүүсийг дотор нь ороод гарсан мэт мэддэг ч гэлээ тэднийг сэжигтэй хэрнээ зүтгүүтсэн хачин харцаар зугуухан тойруулж хараад үл таних Варя, Зоя хоёр дээр хараа тогтов.

Тэгээд Варягийн хажууд суулаа.

–Юу ч захиалаагүй шив хэмээн Костя байдлыг тодорхойлж өгүүлэв.

–Рина шүүхийн хуралд суужээ, тэгээд Алевтинагийн тухай бидэнд ярьж өгч байгаа юм гэж Лёвочка учирлав.

Түс тас зантай Ика,

–Чамайг хүлээцгээж байна гэж үнэнийг хэлэв. Костя Икаг анхааралтай ширтсэнээ,

–Алевтинаг харамсах юм, сайн охин байж билээ. Тэр бухартай битгий холбогд гэж би сануулаад байхад үгэнд ороогүй юм гэв.

Тэрээр Оросын өмнөд нутгийнхан шиг уруулаа цорвойлгосхийгээд үгээ сунжруулан зугуухан ярьж байв. Хүрэн бор нүдтэй, алтлаг цайвар хонгордуу үстэй аж.

Мань хүн Варя руу эргэв.

–Охидууд өлөрхөж байгаа байлгүй.

–Би юм идмээргүй байна гэж Зоя маяглав.

–Би бол идмээр байна, юу ч байсан идчихээр жигтэйхэн өлсөж байна гэж Рина ялархав.

–Юмхан оролдох нь зүйтэй гэж Ика хэлэв. Мань хүн эднийхээ дотроос Костягийн эрхшээлд ороогүй ганц хүн бололтой.

Зөөгч ирлээ.

–Эхлээд тамхи авчирзанж бай гэж Костя тушаав.

–“Герцеговина флор” уу?

–Тийм.

Костя зориуд ингэж сунжруулж байв. Бүгдээрээ хэлэн дээрээ юм тавих гэж яарч байгаа, мань хүн үүнийг мэдэж байгаа учраас яарахгүй байгаа ажээ.

Тамхины хайрцгийг хумсаараа онгойлгоод тамхилцгаа гэсэн шиг ширээн дээр хаяв. Тэгснээ

ганцхан Варягаас,

–Тамхи татдаг уу? гэж асуув.

Гэхдээ тамхи битгий татаасай гэсэн бололтой үгүй гэх болов уу гэж байгаа юм шиг асуусныг Варя анхаарав.

Тэгсэн мөртлөө Варя тамхинаас авлаа.

–Би таныг татдаггүй байх гэж бодсон юм.

–Яасан тоогүй юм бодоо вэ хэмээн Варя адгийн аальгүй шиг инээд алдав.

Костя түүнээс хараагаа зугуухан зайлуулж түрүүчийн адил үгээ сунжруулан,

–За ингэхэд юу идэж, юу ууцгаах вэ? гэв. Лёвочка хоолны цэс уншиж эхлэв. Костя түүнийг зогсоож,

–Царцуу, салаат гэснээ хүний тоо авч ширээг тойруулан хараад, – Хоёр шил цагаан архи, нэг шил дарс. Хар уу, улаан уу? гэж асуув.

–Хар нь дээр гэж Рина хэлэв.

Костя Варя руу эргэж,

–Та яах вэ? гэв.

–Надад ямар нь ч ялгаагүй.

–За тэгвэл хоёр шил архи, нэг шил хар дарс. Халуун хоолноос хайрсан мөрөг загас.

–Оо-ёо-ёо! гэж Вилли Лонг дуу алдав.

–Костя, битгий даналз гэж Мирон өгүүлэв.

–Би дайлж байна гэж Костя хариулав.

–Таны төрсөн өдөр үү? хэмээн Варя үнэнхээсээ юм шиг асуув.

–Тийм. Төрсөн өдөр. Зарим нэг утгаараа.

Энэ хүн зорьсон юм руугаа шууд явж байна гэлтэй. Нүдний аньсаганы тухай ярихгүй нь. Хэрэг гарвал Варя дор нь няцааж чадна. Одоохондоо тэгэх хэрэгцээ алга, Костя даналзахаас цаашгүй байгаа юм чинь.

Огцорсон зандалчны дүртэй нэг этгээд ирж Костя руу тонгойн чихэнд нь нэг юм шивэгнэв.

–Үгүй, өнөөдрийнх болоо гэж Костя хариулав. Сайхь этгээд агаарт замхрах мэт арилав.

Костя бусдад мэдэгдэлгүй Варяг санамсаргүй цочоож, өвдөг дээрээс нь гар цүнхийг нь авч баглаатай мөнгө шургуулаад,

–Өнөөдөр тоглохгүйн тулд ингэчихье гэж аяархан хэлэв.

Варя бүр балмагдчихав. Костя тоглоё гэх юм бол мөнгөө тэртэй тэргүй буцаагаад л авчихна, тоглоё гэхгүй бол өөрийнх нь халаасанд л хэвтэж байна биз. Итгэл үзүүлж, хамсаатан болгож байгаа муусайн хийсвэр банди нарын арчаагүй арга. Хулгайч нар л орогнодог хүүхэндээ мөнгөө ингэж хадгалуулдаг байх. Гэвч нөгөөдүүлийнхээ нүдэн дээр мөнгийг нь буцааж өгөх эвгүй байв. Өөр шиг нь бусдад мэдэгдэхгүй сэмхэн өгч мань хүн чадахгүй. Тийнхүү тэр мөнгө цүнхэнд нь үлдэв. Варягийн сэтгэл гонсойчихов.

Зөөгч зууш, дарс энэ тэрийг ширээн дээр тавилж байна. Костя сайхан зэхсэн ширээнд дуртай, эзэн хүн шиг зөөгчийн гарыг дагуулан харна. Эдний бүлгийнхэн “Метрополь”, “Эрмитаж” энэ тэрд байхдаа хүн нь байнга солигдож нэг нь явж, нөгөө нь ирж, ямар ч эмх замбараагүй байсан атал энд цөмөөрөө номхон томоотой сууцгаах ажээ. Варя үүнийг үзээд түрүүн энэ бүлгийг санаандгүй нийлсэн хэдэн хүн гэж санаж байсан нь биш болж, энэ бол Костягийн бүлэг, түүнийг тойрсон хэсэг хүн юм байна гэдгийг сая ойлгов. Гагцхүү Мирон өөрийнхөө элдэв ажил явдлаар хааяа ийш тийш явж Ика бие даасан хүн гэдгээ үзүүлэхийн тулд зэрэгцээх ширээний улсууд руу очиж суув.

Цагаан хормогч, өндөр цагаан малгайтай тогооч урт бариултай тор авчирч үзүүлэхэд ёроолд нь амьд загас савчиж байв.

–Энэ ямар нэртэй загас вэ? гэж Костя Варягаас асуух зуур хүн өрсөөд хариулчих вий хэмээн бусад руу нь хуруугаа гозойлгон дохиж анхааруулав.

–Та мөрөг захиалсан шүү дээ, бодвол тэр чинь биз гэж Варя хариулав.

–Гэхдээ ямар мөрөг вэ, ердийнх үү, тольт уу?

–Мэдэхгүй.

–Энэ бол тольт мөрөг, сэрвээ нь хурц өндөр байгааг харж байгаа биз дээ, бас хайрс нь том том байна. Ердийн мөрөгний нуруу хавтгай, хайрс нь жижигхэн байдаг юм хэмээн Костя тайлбарлаад,

–Ойлгомжтой юу? гэв.

–Ойлгомжтой. Баярлалаа. Би одоо загасны аж ахуйн дээд сургуульд орж чадахаар боллоо.

Костя тогооч руу толгой дохиход цаадах нь загасаа авч одов.

–Та загас баригч уу? гэж Варя асуулаа.

–Би загас баригч биш, би загасчин, Керчийн хүн, миний аав ч загасчин, өвөө ч загасчин, би жаахан байхдаа тэнгис рүү явдаг байсан юм.

–Мөрөг хэзээнээс эхлээд тэнгисийн загас болчихоо вэ? гэсээр Ика ширээ рүүгээ буцаж ирэв.

–Би тэнгис рүү мөрөг барих гэж явж байсан юм биш гэж Костя тамшаан ярвайгаад Ика руу ууртай харснаа,

–Би улаан нүдэн загас барих гэж явдаг байсан юм. Улаан нүдэн, башинга хоёр ямар ялгаатайг мэдэх үү? Мэдэхгүй юу? За хөгжимчид ирлээ, явж бүжиглэ, би чамд дараа тайлбарлаж өгөмз гэв.

Лёвочка, Ика, Вилли гуравтай Варя бүжиглэв. Костя чаддаггүй учраас бүжиглэхгүй байв. Гэтэл энэ нь Варяд яагаад ч юм билээ, ер дутагдал гэж бодогдохгүй, харин ч болбоос Костяг бусдаас нь дээгүүр тавих шинж шиг санагдана. Тэрээр ширээний ард ганцаараа үлдээд зөвхөн Варяг зэрвэсхэн харж, түүн рүү мишээхийн тулд л толгой дээш татна. Чингэвээс мөнгөөр нь наргиж байгаа хэрнээ эзнийг нь ганцаар нь орхиж, бүжгийг нөхрөөсөө илүүд үзэцгээж байна гэсэн бодол толгойд орж, Варя Костяг өрөвдмөөр болоод явчихав.

Дараачийн бүжигт бүх хүн босоход Костя түүний гараас тогтоож,

–Надтай суузна л даа гэв.

Варя хоцорлоо.

–Та ажил хийдэг үү, сургуульд сурдаг уу?

–Би дунд сургууль төгсөөд одоо ажилд орох гэж байгаа.

–Хаана?

–Зураг төслийн газар, манай сургууль шугам зураг зохион бүтээх чиглэлтэй юм л даа.

–Дээд сургууль яалаа?

–Одоохондоо орьё гээгүй.

–Яагаад?

–Цалин нь жаахан юм. Ийм хариулт танд болох уу? Ер нь энэ бол дэмий яриа. Та бас зураг төсөл зохиогч уу?

–Зураг төсөл зохиогч ий? хэмээн мань эр тамшаалж,

–Үгүй ээ, би өөр мэргэжилтэй гэв.

–Бильярд уу?

Мань хүн егөж байгааг ойлгон нүдэнд нь уур буцлан муухай харснаа биеэ барьж уураа дарав. Тэгээд үгээ сунжруулан зөөж,

–Бильярд бол мэргэжил биш. Нэг боловсролтой хүний хэлсэнчлэн бильярд бол урлаг гэж хэлэв.

–Би бол бильярд чинь тоглоом гэж бодсон юм хэмээн Варя зөрөв. Тэрээр түүнийг нэг их онгироохгүйн тулд дургүйг нь хүргэмээр санагджээ. Миний мэргэжил бол эмнэлгийн цахилгаан тоног төхөөрөмж, хөх гэрэл, солюкс, кварцын дэнлүү, уулын нар, шүдний өрөм энэ тэр гээд байдаг даа. Та шүдний өрөмд дуртай юу? гэж Костя төлөв байдлаар өгүүлэв.

–Үзэн яддаг.

–Би ч гэсэн тэр. Би түүнийг засдаг юм. Тэгээд өөрийнхөө тухай хангалттай ярилаа гэж үзэв бололтой,

–Ринаг аль эртний мэдэх үү? гэж асуув.

Мань бүсгүйг эдний бүлэгт яаж нийлснийг мэдэх гэсэн хэрэг байх нь.

–Үгүй ээ, дөнгөж өнөөдөр танилцлаа. Тэр чинь Зоятой цуг ажилладаг, Зоя бид хоёр нэг байшинд суудаг юм.

–Нэг байшинд ий? гэж Костя яагаад ч юм бэ, гайхаж,

–Хаана тэр вэ? гэв.

–Арбатад.

–Арбатад ий? хэмээн яагаад юм бэ, дахин гайхаж,

–Аавтайгаа нь уу, ээжтэйгээ нь үү? гэж асуув.

–Надад аав ээж байхгүй, тэд аль эрт өөд болцгоосон. Би эгчтэйгээ байдаг юм.

Костя түүн рүү үл итгэсэн янзтай харав. Рестораны охидууд эсвэл онцгой аз, эсвэл гойдын зовлон гэхчлэн аль нэг юмаар тодрохыг хичээж, дор бүрдээ хувь тавилантай улс болох гэдэг билээ. Арван долоон насандаа бүтэн өнчин байна гэдэг бол бас хувь тавилан.

Гэтэл энэ дэргэд нь сууж байгаа охин бол рестораны охин биш.

–Минийх бол цөмөөрөө амьд байгаа. Эцэг эх, долоон ах, эгч, дүү нар, өвөө, эмээ гээд цөм бий, мөн ч олон хамаатан байгаа биз гэж Костя өгүүлэв.

–Тэд нар чинь цөмөөрөө Керчид үү?

–Үгүй ээ, шилжчихсэн хэмээн Костя битүүхэн хариулаад,

–Харин Москвад бол манайхнаас хэн ч байхгүй. Бас юу ч байхгүй. Тэр ч байтугай орох орон ч байхгүй гэв.

–Тэгээд хаана аж төрдөг болж байна?

–Сокольникт нэг өрөө хөлсөлж байгаа. Варя гайхшран бүлгийж,

–Та ийм олон найзтай байж, эд нар чинь хотын төвд ганц өрөө олоод өгч чадахгүй байна гэж үү? гэв.

Софья Александровнагийн сууж байгаа авгай мөд явах учраас Костяг тэднийд суулгах санаа Варягийн толгойд орж ирлээ. Софья Александровнатай урьдчилж ярилцахгүйгээр Костяд юм амлахын хэрэггүй нь мэдээж боловч хүний ач боддоггүй түүний найз нарыг давах гэсэн хүсэл нь дийллээ.

–Баттай амлах юм надад алга. Гэхдээ манай байшингийн нэг авгайгаас би сураглая. Тэднийд нэг сул өрөө бий, танд хөлслүүлж магадгүй.

Цаадах нь түүнийг дахиад үл итгэсэн янзтай жишиж харлаа.

Үгүй ээ, энэ охин үнэнхээсээ яриад байна.

–Тэгвэл мөн башийхсан, ёстой тэнгэрийн юм атгасан хэрэг болно. Тэр авгайнх чинь утастай юу?

–Би эхлээд өөрөө тэр авгайтай ярилцах ёстой. Цаадах нь инээд алдав.

–Та намайг ойлгосонгүй, тэдний рүү утасдах гэсэн юм биш. Ажлынхаа шаардлагаар надад утас хэрэгтэй байдаг юм.

–Утас бий.

Өрөөний тухай дэмий л хэллээ. Юу ч бүтэхгүй ч юм билүү?

–Та чинь яаж байгаад загасчнаас цахилгаанч мэргэжилтэн болчихсон хүн бэ?

–Загасчин... Тэнгисийн хаяанд аж төрж байсан болохоор тэгээд л загасчин болчихож байгаа нь тэр.

–Би тэнгис дээр хэзээ ч очиж үзээгүй гэж Варя өгүүлэв.

Цаадах нь гайхаж,

–Ерөөсөө нэг ч удаа тэнгис үзээгүй гэж үү? гэв.

–Зөвхөн кинонд л харсан.

Одоо Костя бүсгүй рүү яг эгцлэн харж байна.

–Үзмээр байна уу?

–Хэлээд яахав!

Хөгжим зогсов. Нөгөөдүүл нь бүгд ширээ рүүгээ буцаж ирцгээв.

Костя сандлынхаа түшлэгийг налан хундагаа барив.

–Манай шинэ танилууд Варя, Зоя хоёрын төлөө ууцгаая.

–Ура! хэмээн Бага Воля доогтой хашгирав. Аль хэдийн уудгаа ууж, иддэгээ идчихээд ширээн дээр баахан замбараагүй юм овоорч хөндлөнгийн зарим нэг хүмүүс ирж яриа хөөрөө болж байгаа учраас энэ хэдийг өөрснийг нь ч бодсон, цаг хугацааны байдлыг ч бодсон хундага өргөнө гэдэг даанч зохимжгүй зүйл болжээ.

Костягийн дэргэд профессор царайтай, нүдний шилтэй нэг залуу гэнэтхэн гараад ирэв. Тэрээр гартаа нэг мөнгөн дэвсгэрт (Варя өнгөөр нь аравтын дэвсгэрт гэж таньжээ) хумьж барьчихаад,

–Тэгш үү, сондгой юу? гэж асуув.

–Би тоглодоггүй гэж Костя хариулав.

Тэгснээ бодлоо өөрчилж,

–Аль вэ, байзаарай!.. Варя, ямар нэгэн хүслээ дотроо саначих. Санав уу? гэв.

Варя юу ч санаагүй хэрнээ,

–Саналаа хэмээв.

–Одоо хэлээрэй, тэгш үү, сондгой юу?

–Тэгш.

–Тэгш ий? гэж сайхь залуу лавлаж асуув.

–Тэгш гэж Костя нотоллоо.

Нөгөө залуу арван рублиэ ширээн дээр тавилаа. Костя тэр хоёр аравтын дэвсгэрээс юу үзсэн юм бол? Костя хямсайсхийн аравтын дэвсгэрийг базаж аваад Варяд хандан,

–Би мөнгө хожиж, таны санасан хүсэл чинь биеллээ. Юу санасан бэ? гэв.

–Ажилд авах болов уу, үгүй болов уу гэж бодсон хэмээн толгойд эхэлж орсон зүйлээ Варя хэлэв.

–Та тийм юм санасан байж таарахгүй, тэртэй тэргүй авах юм чинь.

Костягийн урам хугарчээ.

–Энэ чинь яадаг тоглоом бэ? гэж Варя асуув. Костя аравтын дэвсгэрийг толийлгоод ноймерийг нь харуулахад 341672 гэсэн тоо байв.

–Энд зургаан тоо байна, та тэгшийг нь сонгож авсан, тэгэхлээр дөрөв, зургаа, хоёр бүгд нийлээд арван хоёр болж байна. Сондгой нь энүүнд өөрт нь үлдэж байгаа юм, тэгэхлээр гурав, нэг, долоо бүгд нийлээд арван нэг. Таных их байна, та хожсон хэрэг, энэ аравт таных. Хэрвээ энүүнийх илүү байсан бол бид нар арвыг өгөх байсан юм, ойлгов уу?

Варя инээд алдав.

–Дээд тоо ч биш л байна даа.

–Тэрүүгээрээ амар байхгүй юу, алга дэлгэмэгц л хожсон, хожигдсоныхоо аль болохыг дор нь харна хэмээн Костя хүүхэд шиг баярлан өгүүлэв.

–Энэ нарийн тоглоом чинь ямар нэртэй байх вэ?

–Төмөр. “Шмен дефер” биш зүгээр л “төмөр”.

–“Савой” маягийн төмөр гэж Варя хэлэв.

Костя инээд алдлаа.

–Дуулцгаав уу? Лёва, сонсов уу? “Савой” маягийн төмөр.

–Та “Савой”, Савойя хоёрын алийг нь хэлсэн юм бэ? гэж Ика инээмсэглэн асуув. Энэ нь ресторан “Савой”, Савойя (газрын нэр) хоёрын ялгааг өөрөөс нь өөр хэн ч мэдэхгүй, тэгэх тусмаа Костя бол бүр гадарлахгүй гэсэн санаа юм байж.

Ика Костяг дооглож байгаад дургүйцсэн Варя,

–Би ресторан “Савойг” л хэлсэн юм гэв.

–Мэдээж ресторан “Савой” байлгүй яахав дээ хэмээн Костя бушуухан тосгуулж өгүүлэв.

Мань хүн хэдийгээр Савойя гэж юу байдгийг төсөөлөх ч үгүй боловч угийн сэргэлэн болохоор ялгаатай зүйл гэж ухаарчээ. Тэрээр ширээнээс хөндийрсхийн гэдийж Варягийн сандлын ар дээр гараа тохоод сууж байгаа боловч биед нь хүрэхгүй байх ажээ.

Болхи аргаар түүнийг эзэмдэж авах гэж байгаа нь энэ, шазруун, шургуу ч гэсэн биеэ барьж чаддаг эр байх нь. Варя түүний бүх аргыг ойлгож байлаа. Гэхдээ мань хүн бусдын адил ямар ч атугай түүний мөнгөөр энд цэнгэж байгаа болохоор Костяг гомдоомооргүй санагджээ. Түүнээс гадна бэлжүү төдийгүй сайхан сэтгэлтэй, илэн далангүй байдал энэ тэр нь Варяд бас аятайхан санагдана.

Хөгжим дахиад хангинаж бүгд бүжиглэхээр явахад Костя Варяг дахиад авч хоцорлоо.

–Та үнэхээр тэнгисийг хэзээ ч үзээгүй юм уу?

–Үгүй гэж би танд түрүүн хэлсэн шүү дээ.

Цаадах нь нүд рүү нь эгцлэн харж, үгээ сунжруулан зөөж,

–Севастополь хүртэл галт тэргээр, тэгээд тэнгисийн эргээр Ялта хүртэл маргааш явцгаая гэж Костя цүнх рүүгээ дохин,

–Галт тэрэг өдөр явдаг юм. Сарафан, усанд орох хувцас мэтийн наад захын зайлшгүй хэрэгтэй юмаа аваарай, гэхдээ тэнд очсон хойноо худалдаад авчихсан ч болно доо гэв.

Варя мэл гайхаж цэл хөхрөн түүн рүү ширтэв. Яахаараа ийм санал тавьж зүрхэлж байна вэ? Бүр ингэхдээ хүрэхүйц юм болчихсон хэрэг уу? Ямар шалтаг өгөө вэ?

–Та ээлжит амралтаа цуг өнгөрүүлэх хүнгүй байгаа юм уу? хэмээн чадах мэдэх бүх хорон үг, хамаг дургүйцлээ ийм өгүүлбэрт бөөгнөрүүлж асуув.

Цаадах нь толгойгоо давлиун сэжиж,

–Надад ээлжит амралт гэдэг юм байхгүй, би дуртай цагтаа өөртөө амралт өгдөг, хэнээс ч хамаардаггүй хүн гэж тов тод хэлэв.

Энэ хүний чухам юу нь дур татаад байгааг Варя сая л ойлгов. Мань эр бол хэнээс ч хамаардаггүй чөлөөт хүн бөгөөд энэ чөлөөт байдлаа Варятай хуваалцъя гээд байгаа нь сэтгэл гижигдсэн юм байна. Саяын саналыг зөвшөөрөх юм бол ямар ерөнд орохыгоо бүсгүй ойлгож байв. Гэхдээ үүнээс айх юм байсангүй, энэ бол эрт орой хэзээ боловч тохиолдох зүйл. Харин өөр юмнаас айж байв. Энэ бол мөрийтэй тоглоомчин, баахан мөнгө хожчихоод одоо тэр мөнгөө шинэхэн охинтой үрэн таран хийх гэж байна.

Костя тийшээ цуг явснаар юм дуусахгүй гэдгийг ойлгуулахын тулд,

–Эргэж ирсэн хойноо бусад юмыг худалдаж авцгаая гэж нэмж хэлэв.

Варя хэсэг зуур чимээгүй бодолхийлж байснаа,

–Би таныг ор мэдэхгүй байж яаж тантай хамт явах юм бэ? гэв.

–Харин чи ингээд мэдээд авахгүй юу.

–Та яагаад намайг “чи” гэж байгаа юм бэ? Та бид хоёр чинь хань нөхдийн андгайн хундага тулгаагүй биз дээ.

Костя лонх руу сарвайж,

–Тулгаж болох байна гэв.

Бүсгүй түүний гарыг арагш нь болгох зуур эл даль болсон үг хэлж байгаагаа мэдэрч байвч дэмий л,

–Та намайг ямар хүн гэж үзээд байна? гэж асуув.

–Би чамайг байдгаараа байгаа хүн гэж үзэж байна. Чи бол ариухан ялдам тансаг охин гэж Костя чин үнэнээсээ хэлээд гар дээр нь гараа тавив.

Варя гараа татсангүй. Костя хулчгар банди нар шиг хурууг нь оролдож гарыг нь базсангүй, зүгээр л гараа гар дээр нь зөөлхөн тавьсан нь бүсгүйд сайхан оргиж, аятайхан байжээ. Ингээд зүгээр гараа гар дээр нь тавьчихаад байхад Костяд ч гэсэн аятай байгааг Варя олж мэдэв.

Тэрээр энэ олны дотроос итгэл өгч, сүжрэн тоосон цорын ганц бүсгүйгээ дэргэдээ суулгасан, мөнгө бэл сайтай хүчирхэг эрийн дүрээр шуугиант танхим руу нигүүлсэнгүй тайван харж байх ажээ. Орчлон дээр хэдийгээр баатар хүн гэж байхгүй ч гэсэн энэ нөхөр бол “номхон” гэхийн сургаар гэдэсхийн хөшиж, дарга нараа нүдээрээ залгичих гээд байх хүн биш, бас хуяг нарт туугдаад тавцан дээгүүр чемоданаа чирээд явж байх хүн лав биш ээ...

Костя Варя руу харалгүй гэнэтхэн,

–Магадгүй би чиний дэргэд л хүн болох ч юм билүү гэж бодлогошрон өгүүлэв.

Тэгснээ хөмсгөө зангидаад буруу харчихлаа.

–За яахав, би явья гэж Варя хэллээ.

Саша хударгыг углаж үзээд дүүртэл нь ачсан завь урсгал сөрөн хөнгөхөн явж байгаад бүр гайхчихав. Хошуун дээрх бүүрэг хэмээх өндөр шон дээгүүр татсан оосорт завь уургалагдан урсгалын аясаар эгцрэн голын эрэгтэй зэрэгцээ байдлаар элдэв донсолгоонгүй шуурхай урагшилна. Шуудан хүргэгч Нил Лаврентьевич голын усны мяралзааг донсолгоо хэмээх бүлгээ.

Голоо гарах болбол завиа сэлүүрдэж гатална. Саша, Борис хоёр хөндлөн данзан дээр суугаад сэлүүрээ хоногт нь углаж эндхийн урсгал их ширүүн учраас байдаг тэнхээгээрээ сэлүүрдэж өгнө. Урсгал ширүүн ч ус тунгалаг гэдэг нь нулимс шиг болохоор харгиа гарамны газар голын ёроолын олон өнгийн чулуутай сайр алаглан харагдана. Харин усны өнгө тэнгэрийн аяс даган нэг төмөр шиг сааралтаж, нэг тунаран хөхөрч, нэг цэнхэртэн ногоорч цийлэлзэнэ.

Нил Лаврентьевич наргиа болгож,

–Залуучууд хойно гялалзтал гүйчихнэ дээ гэж маазруулна.

Нил Лаврентьевич гэдэг энэ жортгор сэргэлэн царайтай юм юманд амжимхай давжаа эр бол цагтаа Лена мөрөн дээр алт хайж, бас Колчакийн эсрэг партизанчилж яваад одоо хамтралчин болсон хүн. Партизанчилж явсан тухайгаа бүдэг бадагхан юм ярихыг үзэхүл бусдаас сонссон төдийгөөр худлаа ярьж байгаа бололтой, харин алт олборлохын хувьд бол үнэнээ ярьж байв. Ангарынхан залуу байхдаа алтны уурхайд явдаг заншилтай байсан юм. Хуруундаа алтан бөгжтэй ирж гэмээж нь алт олборлож байсан нь үнэн бөгөөд тэгэхлээр гэрлэж болно гэнэ! Тэр ёсоор Нил Лаврентьевич алтны уурхайд байж байгаад буцаж ирж авгай авсан, амь зуулгын зургаан үнээний аж ахуйтай болжээ. Эндхийн ханшаар бол арван үнээтэй хүн ч нударган биш түүнээс гадна мань хүнд зарц байхгүй, цөцгий ялгах сүүний машин байхгүй, хамниганчуудтай наймаа хийдэггүй болохоор нударган энэ тэрийн тухайд ярих юм байхгүй. Намар нь тайга руу одож өвлийн турш сайхан хэрэмчилж зургаа, долоон зуун арьсны олзтой ирнэ. Одоо булга хавийн хэрмийг хөнөөж, хэрэмтэй газар бүр умар зүг алслан хойшилчихсон, гэтэл хамтрал ажил хийхийг шаардаад байдаг. Урьдын цагт бол хадлан дээр очиж хадуур хэд даллахаас бусад аливаа гэр орны ажил авгай нарт байдаг сан. Одоо ялгахын арга байхгүй, эр эмгүй л хамтралчин болцгоожээ.

Ийнхүү Нил Лаврентьевичийн цуурахыг сонсон дээрээс өнгийсөн цавчим хясааны ёроолоор буюу хад асган дундуур эрэг даган, эсвэл хясаа нь усандаа тулчихсан газар бол ус туулан явж байлаа. Өдрийн цагт нар орой дээр хөөрөн халуун төөнөж орой болохын үес ойн цаад руу шингэхэд моддын завсраарх хөх ягаан туяа голын эргээр эрээлжлэн байна.

Хааяа нэг загасчны өнчин завь үзэгдэж эрэг орчим модон хөвүүр нүдэнд өртөнө. Энэ бол тэнд томорцог буюу сагс буйн гэрч, бас дээр нь ганц морь уяатай хавтгай ёроолт авсаархан онгоц тэртээ алсад явж харагдана, бусад цагт хүн ч байхгүй, араатан жигүүртэн ч байхгүй эл хуль. Их салхинаа шуугих тайгын чимээ шиг голын боргио шаагиж, том том үхэр чулуу, бул хадны дээгүүр голын ус хуйлран довтолгож, нарны гэрэлд түмэн очис цацлан эргүүлэгтээ харгин буцалж байна. Харгиатай газар оосроос цөмөөрөө татацгаах бөгөөд Нил

Лаврентьевич завин дээрээ гарч зогсоод урд хошууны сэлүүрээр залуурдана. Илаарь биетэй, дуу цөөтэй, том алчуураар бие толгойгоо ороосон авгай нь хүртэл хударганд орж зүтгэнэ. Борис мөрөө холгож замын хад чулуунд хөлөө шалбалсан тул тун урамгүй,

–Володя Квачазе бол завийг ингэж чирэхийн оронд өөрийгөө чирүүлж байгаа даа гэж үглэнэ.

–Хэдий хударганд орсон ч гэсэн хуягаас салсан байна шүү дээ гэж Саша хариулна.

Гольтявино гацаанд ирэхэд тэдний завийг голын эрэг дээр тэндхийн цөллөгийнхөн хүлээж байв. Урьд цуутай эсер үзэлтэн явсан хамиал буурал авгай, бас давжаа биетэй, нүдэнд дулаахан хөгжүүн царайтай, нэг буурал анархист өвгөн, Фрида гэдэг нүд алдам сайхан бүсгүй ийм гурван хүн байв. Авгайн нэр Мария Фёдоровна, өвгөнийх Анатолий Георгиевич.

Шуудан хоёр сар ирээгүй учраас Нил Лаврентьевич тэр гуравт дор бүрд нь багц багц захиа, баахан сонин сэтгүүл гардуулж Фридад түүнээс гадна бас боодолтой илгээлт өгөв.

–Гурав хоног өглөөнөөс аваад орой болтол харуул харцгааж байна гэж Анатолий Георгиевич хөгжилтэй өгүүлэв.

–Натолий Егорыч минь, ялгахаас болоод саатчихлаа, одоо Дворец хүртэл явах болж байна гэж Нил Лаврентьевич тайлбарлав.

Энэ мэдээг шуугилдан хэлэлцэцгээлээ. Хэрэв заяа одоо Дворец тосгонд шуудангийн салбартай болсон юм бол өвлийн шуудан Тайшетийн замаар түргэн ирдэг болох юм байна. Нөгөө талаас шуудангийн салбар байгуулна гэдэг чинь дэвсгэр нутгийн засаг захиргааны өөрчлөлт хийхийн угтвар ажил байж болно. Дворец шинэ районы төв ч болж мэдэх юм. Тэгэх юм бол шинэ дарга, шинэ шүүртэй болно гэсэн үг, тэгээд тэр шүүр нь бидэндээ улам ойрхон ирэх нь.

–Юмаа авцгаа, та нарыг хонуулна шүү гэж Мария Фёдоровна хэлэв.

–Баярлалаа. Нил Лаврентьевич биднийг нэг айлд аваачна гэсэн гэж Саша хариулав.

–Ефросинья Андриановнагийн уу?

–Тэднийд гэж Нил Лаврентьевич завинаас богцтой шуудангаа гаргах зуур нотлов.

–Болж дээ, тэгвэл орой жаахан сууцгаая, та нарыг Фрида очиж авчирна. За юу, Фрида?

Фрида өөртөө ирсэн захиаг уншиж байв.

–Фрида, сэрээч та!

–Өө, за за гээд бүсгүй захидлаа дугтуйд нь хийж Мария Фёдоровна руу том цэнхэр нүдээ дүрлийлгэв. Турьхан бэлхүүсэнд нь элбэгжүү таарсан хуучивтар цамцан дээр тас хар үс нь намиран унажээ.

–Эднүүсийг аваад ирээрэй хэмээн Мария Фёдоровна давтан өгүүлээд,

–Анатолий Георгиевичийнд жаахан сууцгаая гэв.

–Манайд, манайд хэмээн Анатолий Георгиевич сэтгүүлээ эргүүлж байна.

–За нөхөд минь, уншиж амжина даа, явцгаая! гэж Мария Фёдоровна захирангуй өгүүлэв.

Борис илгээлтийг газраас авав.

–Танд бас өөрийн чинь юм байна шүү дээ гэж Фрида хэлэв.

–Тэр юу шалих вэ!

Борис илгээлтийг сэвхийтэл мөрөн дээрээ тавиад чемоданаа барилаа. Нөгөө ядарсан энэ тэр ч ор сураггүй болжээ.

–Чемоданаа одоохондоо орхичих, эргэж ирээд аваад явна биз гэж Мария Фёдоровна зөвлөв.

Саша Нил Лаврентьевичид завиныхаа ачааг буулгахад нь хамжиж өгөв. Борис эргэж ирээд тэр хоёр хамаг юмыг эрэг дээрх нэг байшинд хуу зөөж оруулав.

Гэрийн эзэгтэйг загасаа цэвэрлэж оройн хоол хийх зуур Саша, Борис хоёр гадагшаа гарав.

–За! гэж Борис Саша руу шалгаасан янзтай харав.

Саша асуултыг ойлгоогүй дүр үзүүлэв.

–Зочломтгой, сайхан эелдэг улс байна.

–Нээрэн, нөгөө Чуна голын тэндэх Володягийн танилуудаас тэс өөр улс байна, эд нар бол жинхэнэ сэхээтнүүд, та хэний талыг баримталдаг нь эдэнд падгүй, эдний хувьд бол та өөрсөдтэй нь адилхан цөллөгийн хүн гэдэг л чухал зүйл. Эд нар бол хүн!.. Харин та Фридагийн тухай юу хэлмээр байна?

–Гоё бүсгүй.

–Дүйх үг огт биш! хэмээн Борис дуу алдаж, –Тэнгэр! Дагина! Дуу дууны дуу! Энэ чинь мянган жилийн зам, түмэн янзын зовлонг даван туулж байж шалгардаг юм гэв.

–Таныг ийм үндсэрхэг хүн гэж мэдсэнгүй шүү хэмээн Саша инээд алдав.

–Орос бүсгүй бол үндсэрхэг биш, еврей бүсгүй бол үндсэрхэг хүн болох нь уу. Би түүний хэв янз, үүлдэр угсааг хэлсэн юм. Манай авгай бас еврей айлын хүн, гэхдээ тэр бол Фридагийн чигчий хуруунд ч хүрэхгүй. Ямар сайхан намба хөдөлгөөн бэ! Ямар сайхан ихэмсэг гоёмсог байдал вэ! Энэ бол жинхэнэ хүн! Гэргий, эх, эзэгтэй.

–Еврей хар хүн шиг ярьж байх шив.

–Тийм, яана гэж?

–Та ялын хугацаатай, тэр бүсгүй бас хугацаатай. Таных Кежмагийн район, түүнийх бол Богучаных.

–Тэр юу ч биш! Бид ханилчих юм бол биднийг нийлүүлнэ.

Саша Борисын ийнхүү зөгнөж дүвчигнэж байгаад гайхсан боловч,

–Тэр чинь нөхөртэй байж болно шүү дээ гэхээс өөр юм хэлсэнгүй.

–Тийм байвал ч муу шүү.

Загас, цөцгий, нэрсний чанамал энэ тэрийг тавгалжээ. Нил Лаврентьевич тэдний авгай хоёр загасныхаа ясыг ширээн дээрээ тургин хаяж байна. Саша ийм юманд хэдийн дасжээ.

Гэрийн эзэгтэй гэж учир мэдэх бүдүүн авгай хүүгээ хамтралд ажил хийх дургүй. Уурлагчид ажилд Орос руу барилга руу дуудаад байна.

–Ёстой булай улс, дэмий тэнэж өчүүхэн зүйлээр хөөцөлдөхөөс цаашгүй хэмээн Нил Лаврентьевич ажилд уургалагчдын тухай бодлоо өгүүлэв.

Гэрийн эзэгтэйн хүү гэж яг цыган шиг нэг банди ээжийнхээ үглэхийг чимээгүй сонсон Саша, Борис хоёр руу сониучирхан хялмалзаж сууна. Бас цыгантай төстэй гэрийн эзэн вандан дээр суугаад тамхиа нэрнэ. Борис Фридаг хүлээн үүд рүү хялалзана. Эзэгтэй хүүгийнхээ тухай үглэсээр л байна.

–Хэд хоногийн өмнө энэнээс шүдэнз олсон, халаас нь цоорчихсон байсан, тамхи нуугаад л халаасаа цоо түлээд байгаа хэрэг. Эндээ байж болдоггүй яачихсан хүн гээч юм бэ? Ажил хийлгэж байгаа юм бараг байхгүй, өвгөн бид хоёр хамаг юмаа амжуулчихдаг юм чинь. Үүрийн гэгээ ороогүй байхад л бид чинь талбай дээрээ байдаг улс. Дарга даамал шаардаж шахах хойно, яая гэхэв.

Хүү нь Саша, Борис хоёр луу чимээгүй жишүүхэн харна. Гэрийн эзэн өөрөө сэтгэлдээ тэнэхийн донтой болохоор бас л чимээгүй сууна. Гэтэл мань авгай аанай л үглэсээр. Ингээд явчихаараа муу улстай нийлж тэгээд шорон оронд орчихно доо.

Фрида орж ирж мэндлээд улсын ярианд саад бололгүй вандан дээр суув. Тэрээр хариугүй хуучин пальтотой, савхин гутал духсаны гадна алчуураараа толгой хүзүүгээ ороожээ. Тэгээд алчуураа тайлалгүй ороолттой чигээрээ сууж, нөгөөдүүлээ хоолоо идэж дуусахыг хүлээв.

Борис өндийж Саша руу яаруулах янзтай харлаа.

Хоймор бурхан тахил, нөгөө буланд жижигхэн ширээн дээр толь, дугуйтай утас, хажууд нь хатгамалтай нүүр гарын цэвэрхэн алчуур, цонхны тавиур дээр чулуу, эрдсийн дээж,

жижигхэн хайрцагтай үр, вааранд тарьсан суулгац энэ тэр байх ажээ.

–Манай Анатолий Георгиевич бол агрономич, геологич, эрдэс судлагч, палеонтологич хүн, юу юу ч билээ би мэдэхгүй, хожим өөрийг нь үнэлнэ гэж найдаж байгаа юм хэмээн Мария Фёдоровна жуумалзав.

–Энэ нутгийг л үнэлж үзээсэй, Ангарынх шиг ийм баялаг хаана ч байхгүй. Нүүрс, төмөрлөгүүд, нефть, ой мод, үслэг ан, барагдашгүй усны нөөц гэж Анатолий Георгиевич хариулав.

Тэрээр цэмцгэр нарийхан хуруугаараа чулуу, лав, мөнгөн судалтай эрдсийн хэлтэрхий энэ тэрийг барилж тавилан, санаандгүй таарсан энэ сонсогчид өөрийг нь их анхааралтай сонсож буйд баярлан байна. Дараачийн ийм сонсогчид жилийн дараа ч ирж магадгүй, эсвэл ерөөсөө ирэхгүй байж ч мэднэ.

–Би бүр Хоёрдугаар сарын хувьсгалаас өмнө энэ Ангарад бас цөлөгдөж байсан хүн, одоо ийнхүү дахиж ирчихээд байна. Гэхдээ түрүүчийн удаа бол энэ хязгаарын тухай миний өгүүллүүдийг нийтэлдэг байсан юм, одоо ч энэ тухай бодож ч зүрхлэхгүй байна. Гэлээ ч гэсэн миний тэмдэглэлүүд эрхбиш хэрэг болно гэж найдах юм гэж Анатолий Георгиевич ярив.

–Дорно зүгт металлургийн хоёр дахь суурь газрыг хөгжүүлэхтэй холбогдон байгалийн баялгийг хайх явдал маш чухал хэмээн Борис Фрида руу хяламхийн өгүүлээд, - Кузбассын дараагаар хүнд үйлдвэржүүлэлт ийшээ л ирэх болно. Чухам хэзээ вэ гэдэг л байна гэв.

Тэрээр орон нутгийн сайн дурынхныг зоригжуулж байгаа удирдах ажилтан шиг сая тун дориун ярив. Хөөрхий Борис! Фридагийн нүдэнд мундаг хүн болох гэж байгаа санаа нь тэр, гэтэл мань хүн шал өөр юмаар мундаг шүү дээ.

Мария Фёдоровна дооглонгуй толгой дохив.

–Бас та нарт хүртэл энэ хүнд үйлдвэржүүлэлт, таван жилийн төлөвлөгөө... энэ тэр хэрэгтэй байх нь. Та нарын эрх чөлөөг хасчихаад байна, бодох юм чинь энэ шүү дээ. Та нар тавин жилийн дараа энэ хязгаар нутаг яах бол, энэ Сибирь ямар байх бол... гэх мэтчлэнгийн юм ярьцгааж байна. Харин ариун цагаан нинжин сэтгэлтэй байх эрхийг нь хасчихсан хүн тэр тавин жилийн чинь дараа гэхэд юу болж хувирсан байх тухай л та нар бодоцгоо.

–Ямар ч атугай нүдэн дээр ил байгаа юмыг үгүйсгэж болохгүй, Орост аж үйлдвэрийн хувьсгал болж байна гэж Анатолий Георгиевич өгүүлэв. Энэ хөвсгөр буурал үстэй жижигхэн өвгөн Сашагийн төсөөлдөг анархистуудын дүртэй даанч дүйхгүй байв.

–Та чинь яагаад энд суучихав аа! Больж үз! Академич болоод явчихна шүү! гэж Мария Фёдоровна дуу алдав.

–Үгүй хэмээн Анатолий Георгиевич зөрж, –Эд нар нэг юм мэдэж аваг. Тэрс үзэл бодол гэж байдаг юм, тэрс үзэл бодол байхгүй бол зүгээр үзэл бодол гэж ч байхгүй. Харин заавал

ажиллах хэрэгтэй, хүн бол ажиллахгүй байж болохгүй гэснээ өвгөн суулгацаа зааж, –Энд бас улаан лооль, тарвас үржүүлж байна гэв.

–Та чухам энэ улаан лоолиноосоо болж эндээс хамгийн түрүүнд алга болно доо. Хамтрагчид үр тарианы асуудлыг шийдэх ёстой байхад та улаан лооль гэж хажуугаар нь ороод байх юм. Үр тарианы асуудлыг Орост шийдээгүй атал энэ талх тариа ерөөсөө мэдэхгүй Ангарад тэр асуудлыг шийдэх юм гэнэ гэж Мария Фёдоровна хэлэв.

Тэгээд санаа алдсанаа үргэлжлүүлэн ярив.

–Түрүүхэнтэйгээ цөллөгийнхөн тариачдад ажил хийж өгөх буюу ар гэрээсээ ирсэн юмаар аж төрж, тэднийг тоох амьтан бараг байхгүй болохоор эрхбиш учиртай байсан юм. Гэтэл одоо хамтрал байгуулагдан дарга нар бий болж, элдэв бүрэн эрхт төлөөлөгч нар эргүүл тойруулаар ирэх болсноос хойш аливаа шинэ үг болгон ухуулга гэгдэж, хамтралд юухан ч тохиолдлоо гэсэн буруутныг хайж, гэтэл тэр буруутан нь мэдээж энэ цөллөгийнхөн, энэ эсэргүү нар, эд нар л нутгийн хүн амд нөлөөлж байна хэмээн төмс ургахгүй, загас баригдахгүй, үнээ тугаллахгүй, сүү гарахгүй байсан ч хамаг бурууг тэдэнд тохно. Жишээ нь Фридаг баптист (ухамсар суусан хойно нь загалмайлдаг Христос шашны нэг урсгал) сүсэгтэн гээд байгаа юм, нэг нөхөр энүүнд, та энэ баптист суртал ухуулгаа болиорой! гэж шууд хэлсэн. Тэр нөхөр тэгж хэлсэн биз дээ?

–Тэгсэн хэмээн Фрида инээмсэглэв.

–Цорын ганцхан үр дүнд хүрлээ хэмээн Мария Фёдоровна тамшаалж, — Тэр юу вэ гэхлээр тариачин эр одоо тулалдахаасаа өнгөрсөн. Юуны төлөө тулалдах юм бэ? Урьд газрын эзэн ирээд газраа буцаагаад авчихна гэж айдаг байсан. Гэтэл одоо газрыг нь тэртэй тэргүй булаагаад авчихсан болохоор тариачин эр юуныхаа төлөө тулалдах юм бэ? гэв.

–Энэ бол маргаантай асуудал, ард түмэн, улс үндэстэнд өөрийн гэж хамгаалан тэмцэх эрхэм нандин юм бий гэж Саша өгүүлэв.

–Та бол тэмцэхээр явах уу? гэж Мария Фёдоровна асуув.

–Явалгүй яахав.

–Та чинь юуны төлөө тэмцэх хүн бэ?

–Оросын төлөө, Зөвлөлт засгийн төлөө.

–Үгүй, тэр Зөвлөлт засаг чинь л таныг Сибирь лүү хөөгөө биз дээ.

–Харамсалтай нь тэр ч тийм хэмээн Саша зөвшөөрөөд, –Гэхдээ Зөвлөлт засаг буруутай биш, харин засгийг муухайгаар ашиглаж байгаа хүмүүсийн буруу гэв.

–Та хэдтэй вэ гэж Анатолий Георгиевич асуув.

–Хорин хоёртой.

–Залуухан байна хэмээн Анатолий Георгиевич инээмсэглээд, –Их юм үзнэ дээ гэв.

–Үгүй, юу үзэх юм бэ? Таны хугацаа хэдэн жил вэ? гэж Мария Фёдоровна урамгүй асуув.

–Гурван жил. Таных?

–Надад хугацаа байхгүй гэж авгай хүйтэн хариулав.

–Яагаад тэр вэ?

–Яахав тэгээд л тэр. Хорин хоёр оноос эхэлсэн. Цөллөг, Соловки арал, улс төрийн тусгаарлалт, дахиад цөллөг, дахиад л Соловки арал руу юм уу улс төрийн тусгаарлалт. Одоо бидний эсэргүүчүүдээр Умард нутгийг эзэмшүүлэх юм гэж ярьцгааж байгаа. Таныг ч гэсэн энэ зам хүлээж байгаа. Ийм тойрогт нэг орсон бол түүнээс гарна гэж байхгүй. Харин Фридаг Палестина руу явуулбал тэр тойргоос нэг гарах байж магадгүй юм.

–Та Палестина руу явах санаатай юм уу? хэмээн Саша гайхаж асуув.

–Санаатай.

–Та тэнд юу хийх юм бэ?

–Ажил хийнэ, газар ухна гэж бүсгүй яльгүй тультран хариулав.

–Та газар ухаж чаддаг юм уу?

–Бага зэрэг чадна.

Саша улайчихав. Өөрийнх нь асуулт басамжилсан юм шиг болчихжээ. “Та газар ухаж чаддаг юм уу?” Гэтэл энэ хүүхэн энд ч гэсэн газар ухаж л амь зууж байгаа шүү дээ.

Мань хүн ая алдсанаа засах санаатай,

–Танд Орост байхад муу байна гэж уу? хэмээн зөөлхөн асуув.

–Хэн нэгэн хүнээр өөрийгөө муу еврей гэж хэлүүлээд нүд нүүр лүүгээ чичүүлж байхыг хүсэхгүй байна.

Бүсгүй үүнийг тайван хэлсэн боловч үзэл санаандаа бат итгэсэн хүний нугаршгүй тууштай байдал Сашад ажиглагдав. Борис энэ хүүхний шашинд л элсдэггүй юм бол ямар ч амжилт олохгүй юм байна.

Мария Фёдоровна, Анатолий Георгиевич хоёрын хэн нь ч гэсэн хувьсгалын дараахан тэрс үзэл бодол зайлшгүй зүйл гэгдэж байсан ахархан хугацааны тасархай ажээ. Одоо бол тэрс үзэл бодлыг зүйд нийцэхгүй зүйл гэж үзэж байна. Баулинчууд, столперчууд, дьяковчууд бол өөрсдөөс нь өөр янзаар бодож зүрхэлдэг өтөл дорой хүмүүсийг яллаж байх эрхтэй гэдэгтээ бат итгэсэн хүмүүс.

–Надад нэг хүсэх юм байна гэж Мария Фёдоровна өгүүлээд, –Кежмад очсон хойноо Елизавета Петровна Самсонова гэдэг яг над шиг эмгэнийг хайж олоод үүнийг дамжуулчихгүй юу гэв.

Тэгээд Сашад нэг дугтуй сарвайв.

Мань хүн үүнийг авах албатай юу? Дотор нь юу байгаа бол? Яагаад шуудангаар явуулахгүй байна вэ?

Эргэлзсэн царайг нь Мария Фёдоровна дор нь анзаарав. Тэгээд дугтуйгаа нээж үзүүлэхэд дотор нь мөнгө байв.

–Энд хорин рубль байгаа, үүнийг дамжуулаад намайг одоо хэрнээ амьд явна гэж хэлээрэй.

Саша дахиад л улайчихав.

–За, би хүргээд өгчихнө өө.

Нөгөө хэд дахиад л харгиа боргиог гатлан заримдаа эргээс эрэг рүү хөндлөн сэлж голоо өгсөв. Халуун байсан боловч Нил Лаврентьевичийн авгай алчуураар ороож завины хошуун дээр суусан чигээрээ сууж, мань хүн өөрөө ч гэсэн бэржээнтэн цуваа тайлахгүй байв.

Тэртээ алсаас нэг шуугиан сонсдов.

Мура голын харгиа хэмээн Нил Лаврентьевич санаа зовсон байдалтай өгүүлэв.

Усны ёроолын үхэр чулуу элбэгшин, урсгал түргэсэж байснаа шуугиан нэмэгдэн нэмэгдсээр тасралтгүй нүргээн болж, эцэст нь чих дөжрөм аюумшигт их чимээгээр солигдов. Явах зүгт гол бөөн цагаан үүлэнд умбан, усан дотроос нүцгэн хаднууд ёрдойлцон, тэдгээрт ус хөөсрөн хуйлраад энэ их шуугианыг зэрэг галласан хэдэн зуун үхэр бууны нүргэлээн гэлтэй. Зүүн эргийн хадан хавцал дундаас Мура гол огин буцлах мэт шуугин олгойдож байв. Энэ голын Ангарад цутгах цутгалангийн аман дээр сэрэвгэр хяртай аварга том цохио сүндэрлэн харагдана.

Завиа эргэн дээр чирч гаргаад юмаа буулгаж харгианаас дээш аваачив. Тэгээд эргэж ирцгээж завиа мөн чирч гулдчин тийш нь авчирлаа.

Борис ядрах алжаахыг аль хэдийн мартаж бушуухан Кежма орж төвхнөж аваад Фридагийн шилжүүлгийг хөөцөлдөнө гэж яарахдаа одоо дэндүү удаан явцгааж байна хэмээн үглэж явав. Мань хүн Фридатай гэрлэнэ гэдгийн тухайд ямар ч эргэлзээ байсангүй.

–Тэр хүүхэнд нөхөр ч байхгүй, ам өгсөн хархүү ч байхгүй. Ээж нь Чернигов хавьд аж төрдөг гэнэ. Залуухан хүүхэн ганц бие байхад ямар вэ дээ? Бид хоёр Кежмад аж төрнө, түүнийг ажилд оруулахгүй, гэр орныхоо ажлыг хийж байна биз, тэгээд хүүхэд гарна. Энд ч гэсэн хүүхэд өсөж бойжиж л байна шүү дээ, хугацаа дуусахаар цуг яваад өгцгөөнө. Та Фридаг Москвагийн театрт гоёчихоод байж байхыг төсөөлж байна уу? Сайхан авгай олж авахын тулд Ангарад ирээд буцахад алдах юм алга. Цөллөг - гурван жил, авгай нэг насных.

–Тэр чинь Палестина явах санаатай биз дээ.

–Тэр дэмий! Больчихно. Тэр чинь хүүхэн хүний амьдралын амт хараахан үзээгүй хүн. Гэр бүл, орон байр, хүүхэд шуухадтай болохын цагт Палестины тухай бодол нь ор сураггүй алга болно.

Саша Фридагийн гоёхон царайд шийдвэр төгс байдал илт байсныг санаад Борисын ийм харалган байгаад бүр гайхчихав.

–Тэр чинь бурханд сүсэглэдэг гэж зүтгээд байсан, тэрийг үнэнээсээ тийм гэж бодож байна уу? Иегов бурхныг үнэн санаанаасаа шүтдэг орчин үеийн еврейг надад үзүүлээд өгөөч. Еврей хүний хувьд шашин гэдэг бол үндсээ хамгаалж үлдэхийн төлөө, бусад үндэстэнд уусаж сөнөхийн эсрэг хэрэглэх арга төдий зүйл. Гэтэл уусна гэдэг бол зайлшгүй зүйл. Миний өвөө цадик байсан, гэтэл би еврейн хэлийг мэдэхгүй. Тэгэхээр би ямархан еврей билээ? гэсэн асуулт гарч байна гэж Борис ярив.

–Боря, та түүнийг ганцхан орой л харсан шүү дээ.

–Хүнийг танья гэвэл таван минут ч хүрэлцээтэй. Би таныг комендантын газар үзмэгц ганзага нийлэх хүн байна гэж өөртөө хэлсэн юм. Би тэгээд андуураагүй байна. Би бол цагаан, ногоон, хөх элдэв хүүхнийг үзсэн хүн. Хэрвээ жинхэнэ хүүхэн олох юм бол надад бусад нь ямар ч над байхгүй. Гэрлэлтээ юм үзээгүй банди бол өөр нэг юм үзэнгүүт хормойноос зүүгдээд салахаа больж, авгай хүүхдээ хаяж, гэр бүлээ сарниадаг юм.

Энэ ярианы цаана ганцаардсан хүний цөхрөл байна уу, эсвэл өөр шигээ бөглүү нутагт цөлөгдсөн бүсгүйг өрөвдсөн сэтгэл байна уу, юу ч байлаа гэсэн энэ бол хайр дурлал аргагүй мөн. Ийм ажил хэрэгч, тэгсэн мөртлөө хүүхэмсэг, цэнгүүн амьдралд дуртай энэ хүний хувьд бол тун санамсаргүй дурлал. Мань хүн Фридагийн тухай ярихдаа хамаг царай нь уяран талимаарах ажээ.

Талийгаач Карцевт нутаг болгож заасан Чадобец гацаанаас гадна бас хэдэн тосгон дайран өнгөрөхдөө Нил Лаврентьевичийн танил юм уу хамаатан садангийн айлд хоноглоно.

Саша, Борис хоёр оройн хоол идмэгц унтахаар хэвтэж Нил Лаврентьевич нөгөө айлынхантай зөндөө удаан сууцгаана. Саша хүн орж гарах, хаалга дуугарах, эрчүүдийн хууч ярианы хагас хугасыг нойрон дундаа сонсоно.

Шарсан загасны үнэр бас пийшингийн хаалт, пийшин дотор нааш цааш болгож байгаа ваар энэ тэрийн чимээнээр сэрж эртлэн босоцгоов.

–Сайхан амарцгаав уу, амьтан хазаагүй биз? хэмээн гэрийн эзэгтэй асуув.

–Сайхан амарлаа, гялайлаа.

Өглөө удаан цайлсангүй замдаа яаравчлан гарцгаав. Гадаа хэдийн хүн амьтны дуу гарч байв.

–Ажил руугаа яарцгааж байгаа нь энэ гэж эзэгтэй тайлбарлав.

–Сайхан боллоо, гялайлаа хэмээн Нил Лаврентьевич босох зуур хэврэн хайш яйш залбирар.

Айлаар ингэж хоносныхоо дараа Нил Лаврентьевич завиндаа суусан хойно иймэрхүү юм ярилаа.

–Манай энэ нутагт ямар юмны хамтрал байх вэ дээ? Оростой адилгүй энд чинь тайгын өлөн цэвдэг газар, илүүчлэх талх тариа байхгүй, авгай хүүхэдтэйгээ өөрсдийгөө тэжээвэл их юм. Бид нар улсад юу тушааж чадах вэ, хэрэмнээс өөр юу ч тушааж чадахгүй. Лена мөрөн рүү үхэр туух явдал байсан, тэгж байгаад одоо сүү нүдний гэм болсон. Урьд цөллөгийнхнийг, улс төрийнхнийг хөлсөлж байгаад мод булгалуулдаг байлаа, одоо мод булгалахаа больцгоосон. Бас хуш түнших хүн ч байхгүй болжээ.

Тусгай нүүдлийнхэн буюу Оросоос цөлөгдсөн нударганчуудын гучаад оны үед барьсан Калинины эдлэн хэмээх тосгоныг өнгөрцгөөлөө.

–Тэд нарыг яг нэгдүгээр сарын хуучаар авчирсан юм хэмээн Нил Лаврентьевич өгүүлж, – Харчуулаас арай зоригтойхон хэд нь Кода гэдэг хамгийн ойролцоох тосгонд, эндээс найман мод хэртэй газар, очиж хүүхэд шуухдаа толгой хоргодуулахыг гуйж гэнэ. Гэтэл цаадуул нь айгаад авсангүй, тэнд дандаа ганцхан Рукосуев овогтнууд байдаг, тэднийхний нударганчуудыг бас ялгаж салгаж, хамгийн мундагуудыг нь аваад явчихсан болохоор тэгж айцгааж л дээ. Нөгөө харчуул ой руу буцаж ирээд газар байр ухах юм болж. Гэтэл цас жаварт хөлдүү газрыг ухна гэдэг бүү үзэгд. Үхэх нь үхэж, үлдэх нь үлджээ. Хавар нь ойг үндсээр нь булгалж, хэсэг газар цэвэрлэн хагалж тариа тарьсан, ажилсаг юманд дүйтэй яахаас ч буцахгүй улс. Одоо аж төрөл жигдэрчихсэн, улаан лооль тарьцгааж байгаа. Манай энд уул нь Натолий Егорыч, нөгөө улс төрийн хэргээр цөлөгдөгч л улаан лооль тариалж үзсэн, манайхан бүдүүлэг улс болохоор түүнийг тэглээ гэж эвхэрч ойчин инээд ханиад болж байсан юм, гэтэл энэ нударганчууд одоо нотолчихоод байгаа юм. Тэд улсад ашигтай байгаа нь тэр байхгүй юу гэв.

Тэрээр сүүлчийнхээ өгүүлбэрийг тун дорвитой маадгар өгүүлсэн нь улсын эрх ашгийг өөрөөр хэлбэл нударганчуудын хөрөнгийг хураах шаардлага, мөн улаан лооль тариалахын ашиг хоёрыг ойлгож байгаагаа цохсон хэрэг болой.

Гэхдээ мань хүн хичнээн ч сэргэлэнтлээ гэсэн хүүхэд шуухадгүй тусгай нүүдэлчдийг өрөвдөж өөрөө адилхан хүүхэдтэй, бас тэд нар шиг хүн болох нь илт байв. Бас ийм явдал болж байгаад айхгар цочин балмагдсаны гадна төрөлх нутгаасаа ховх татуулж хаашаа, яасны учир хөөгдсөнөө үл мэдэх Украин, Кубанийн тариачдын энэ хувь тавилан өөрийг нь хүлээж байгаа эсэхийг үл мэднэ. Эндхийнхэнтэй төсгүй шинэхэн дүнзэн байшингуудыг Саша шимтэн харж явав. Гудамж руу харсан үүдний довжоо, хаяаны манаас энэ тэртэй эдгээр оросын ердийн таван ханат байшин бол Оросын хэлтэрхий юм. Энэ бол төрөлх нутгаас нь ховх татаж тайгын цасанд хаясан боловч энд орос хүн шинээр бүтээн, хямгадан хамгаалсан тийм нэгэн хэлтэрхий буюу.

Саша тэр улс одоо ямар байгаа бол хэмээн хармаар санагдав. Гэвч хүмүүс ажилдаа гарчихсан, тосгон нам гүм амар жимэр байх бөгөөд голын эргээр ч гэсэн Ангарын бусад тосгоныхтой нэгэн адил том бага завь, загасны тор энэ тэр харагдана.

Бусдын адилаар л амьдардаг бололтой. Тэсэж үлдсэн нь л тэр шүү дээ. Дэнжийн хажуу дээр баахан хүүхдүүд бужигнаад алга болов. Энэ хүүхдүүд ч гэсэн нөгөө хар цасны жаварт хөлдчихөөгүй тэсэж үлдсэн амьтад байх нь. Магадгүй, энд төрцгөөсөн хүүхдүүд ч байж болно.

Дахиад л дөлгөөн их мөрөн, хөвхөр хясаа цохио, зах хязгааргүй хөвчин тайга, цэнхэр тэнгэрт хөөрсөн нар. Энэ бүх өгөөмөр баян хангай хүний сайн сайхны төлөө л заяасан авай. Намуухан тохой, нэргүй гүехэн харгианууд. Баруун талын эрэг дээр ганцхан Рукосуев овогтноор бүрдсэн Кода тосгон байна. Нөгөө тусгай нүүдлийнхний тусламж хайгаад ам руугаа алгадуулдаг тосгон. Тэр ч гэсэн бас хүн амьтны хөлгүй нам гүм, амар жимэр байх ажээ.

Өчигдөр хөгжим хангинаж, гоёмсог хүүхнүүд ганган харчуултай бүжиглэж байсан ресторанд сууж байхад “За яахав, би явья” гэж хэлэхэд даанч амархан байжээ. Өчигдрийн тэр бол биеэ даасан шинэ амьдрал. Тэгэхлээр Костя өөрөө ч гэсэн, Крым рүү явья хэмээсэн түүний санал ч гэсэн аль аль нь тэр шинэ амьдралын нэгээхэн хэсэг учраас Варя өчигдөр бол түүнтэй тэр ресторанаас гараад хаашаа ч яваад өгсөн чадах байлаа. Харин өнөөдөр гэрэл гэгээ муутай нийтийнхээ орон сууцанд ингээд байж байхад тэр бүхэн хэзээ ч бүтэж биелшгүй зүйл, рестораны хоосон яриа, тоглоом тохуу мэт санагдах ажээ. Викагийн бүлгийнхэн гадаадад явах тухай ингэж худлаа бурцгаадаг шиг Костягийнхан Крым юм уу Кавказ руу явах тухай бас тэгдэг юм байж.

Ер нь ч тэгээд тэр Костя гэдэг чинь хэн билээ? Рестораны бильярдчин, мөрийтэй тоглоомын эзэн. Ямар арчаагүй аргаар хуурах санаатай байсан гээч. Мөнгөө цүнх рүү нь хийж үнэтэй хоол, ховор дарс захиалж, ихэмсэг дүр гарган маяглаад байсан... өөр шиг нь хичнээн охидыг үзэж өнгөрүүлсэн бол? Хичнээнийг Крымд явья гэж хуураа бол? Мань хүн тиймхэн юмны төлөө жолоо алдахгүй ээ! Нэг муу бильярдчин түүний толгойг тэнэг амьтан байгаа мэт эргүүлж чадахгүй! Крым рүү авч явсныхаа дараа хаячих юм бол эсвэл тэндээ орхичихвол мань бүсгүй хэн гээч амьтан болох вэ? Буцах билетийн мөнгө өгвөл ч бас яахав, аягүй бол өгөхгүй, яаж л харьдаг сан, дураараа бол гэнэ шүү дээ. Тэгвэл эгч минь аварч үз гээд л Нинад цахилгаан явуулах хэрэг гарна, тэгж гэмээн ч мань хүн муураад ойчно доо, өчигдөр нь ресторанд танилцчихаад өнөөдөр нь Крым яваад өгч гэж дуулахад ямар ч хүний үнхэлцэг хагарах л даа. Үгүй, ер нь яагаад заавал өнөөдөр явах ёстой билээ? Юундаа яарсан хэрэг вэ?

Тэрээр амласан ёсоороо Софья Александровнатай ярилцана. Хэрвээ түүнд өрөөгөө хөлслүүлэх болбол тэр хоёр ойртон танилцаж тэгсний дараа тэдний хооронд ямар нэгэн харьцаа тогтож магадгүй.

Өчигдөр Костя рестораны дараа Зоя тэр хоёрыг гэрт нь таксигаар хүргэж өгөөд явахдаа,

–Маргааш гэрээсээ битгий гараарай, миний утасдахыг хүлээнэ шүү. Би үдээс өмнө утасдана гэж хэлсэн.

Цаг аль хэдийн арван хоёр болчихоод байна, уул нь одоо Софья Александровна руу юм уу, Зоягийн ажил руу явчихвал яг зүйтэй байхсан. Тэгээд тэр нөхрийг орой утасдвал “Би таны утасдахыг үдээс өмнөжингөө хүлээсэн, та утасдаагүй шүү дээ” гээд хэлчихгүй юу. Гэвч орой утасдах юм болов уу даа? Юу гэж баахан бурснаа өөрөө мартчихсан байх вий. Крым руу тийм амархан гэнэтхэн яаж ч явж чадах юм бэ? Ажлаа хаячихаад шүү! Билет яаж олох юм бэ? Урьдаас суудал захиалсан томилолтын хүмүүс гэхэд л билет арайхийж олдог, жирийн хүмүүс бол галт тэрэгний буудал дээр хэдэн долоо хоногоор зогсоцгоодог шүү дээ. Гэртээ тайван сууж байж болох юм байна. Үүгээр түүгээр гүйж царай алдахын хэрэг юун. Утасдахыг нь хүлээнэ гэж хэлсэн хойно хүлээж л байя. Утасдах нь уу, үгүй нь үү, харин ч сонин байна. Юу гэж худлаа аргалахыг оролдох бол доо?

Костя арван хоёр хагаст утасдаж билетээ гартаа оруулаад авчихсан. Галт тэрэг дөрөвт

хөдөлнө, өөрөө гуравт очиж түүнийг авна. Хэдэн давхарт, хэдэн ноймерт байдгаа хэл гэжээ.

Варя түүний зөөлөн хэрнээ захирангүй аястай дууг сонсмогц балмагдаж орхив. Цаадах нь яг л өчигдрийнх шигээ үгээ яльгүй сунжруулсхийн зугуухан тов тод ярьж байв. Тэгмэгц түүний царай, өөрийг нь зөндөө удаан харж агсан зүггүй хачин хэрнээ үл итгэсэн янзтай харц нь санаанд оров. Бас түүний бэлжүү зан, эршүүд хэрнээ гэнэн байдлыг санав. Варяг Арбатад аж төрдөг гэхэд гайхаж дотроо нэг юм санахдаа өөрийнх нь горьдсон юмыг санасангүй гэж урам нь хугарч гэнэн царайлж байсан. Нөгөө найзууд нь хүний мөнгөөр идэж ууж байгаа хэрнээ тэр хүнээ ганцааранг орхиж байна гэж тэдэнд өөрөө гоморхож байснаа бас санав. “Магадгүй, би чиний дэргэд л хүн болох ч юм билүү” гэж хэлснийг нь саналаа. Бодсоноо ингэж хэлчихсэнээсээ ичиж тэр дорхноо хөмсөг зангидан барайж байсан.

Хэлсэн амнаасаа ухарч, түүнийг хуурч яаж болох вэ? Ам алдсан нь дэмий хэрэг, гэхдээ л амласан шүү дээ! Одоо үгүй гэж хэлэх хэл даанч алга.

–Намайг авах гэж наашаа ирэхийн хэрэггүй, би таныг Никольскийн хөндлөн гудамд өнцгөөсөө хоёр дахь байшингийн дэргэд хүлээж байя гэж Варя хариулжээ.

–За тэгье, харин саатаж болохгүй шүү, тэгвэл галт тэрэгнээсээ хоцорчихно.

Варя үүдээр гарвал Нина мөргөлдчихөж магад хэмээн Никольскийн хөндлөн гудам руу арын замаар явж очихоор шийдэв.

Чемоданы хэрэг байсангүй. Хамаг байгаа юмаа өмсөөд болох нь тэр. Бас нэг даашиг, сарафан, шуудаг, даруулга, хос оймс, шүдний сойз, саван, сам энэ тэрээ цүнх рүүгээ чихчихжээ.

Чемоданы хэрэг гараагүй нь л яамай, арын зам хаалттай байж таарав. Саяхан Арбатад нэг хорооноос нөгөө рүү орох бүх замыг хаачихсаныг Варя санав. Сталин зуслан руугаа явахдаа үүгээр хааяа өнгөрдөг болсон учир Арбат тусгай дэглэмтэй гудамж болсон юмсанж. Никольский хүртэл ердийн замаар явахаас өөр аргагүй болжээ. Аз болоход хэн ч тааралдсангүй. Тааралдлаа ч гэсэн сургуулийнхаа хуучин цүнхтэй явж байхад хүн гайхах юу байх вэ дээ.

Тэрээр Нинад “Найзуудтайгаа Крым явлаа, хоёр долоо хоногийн дараа эргэж ирнэ, битгий уйдаарай, Варя” гэсэн зурвас үлдээжээ.

Варя Никольскийн хөндлөн гудам руу эргэн ормогц нэг таксины дэргэд Костя өчигдрийнхөө “Савойд” өмсөж байсан костюмтайгаа зогсож байхыг үзэв.

Тэр хоёр олон улсын вагонд суужээ. Варя ийм вагон амьдралдаа анх удаа үзэж байгаа нь энэ. Одоо Мичуринск гэдэг нэртэй болсон Козлов хот руу Нина тэр хоёр нэг эгчийндээ очихоор явахдаа нийтийн задгай вагонд суусан билээ. Ер нь таньдаг улс нь тийм л нийтийн задгай вагоноор явцгаадаг юм. Тэрээр дөрөв дөрвөн хүн суудаг битүү тасалгаануудтай вагон байдаг гэж дуулах нь дуулсан. Харин хоёрхон хүний суудалтай, тусгай угаагууртай тасалгааны тухай бол дуулаа ч үгүй юмсанж. Гэтэл мань хүн тийм вагонд, тийм нэгэн тасалгаанд явж байна.

Бөөн хилэн, бөөн хүрэл болсон тасалгаа, тэр ч байтугай хаалганых нь бариул хүртэл хүрэл. Хонгилдоо зөөлөн дэвсгэртэй, цонхондоо хилэн хөшигтэй, ширээн дээр гоё бүрхүүлтэй дэнлүү байна. Дүрэмт хувцастай эелдэг, уриалгахан үйлчлэгч нүсэр суурьтай шилэн аягатай цай зөөж, ялангуяа Костяд сайхан загнана.

Энэ вагонд их чухаг улс, магадгүй алдар цуутнууд явж байна гэдгийг Варя ойлгож байв. Зэрэгцээ өрөөнд цэргийн дээд тушаалыг илтгэх армийн командлагч, түүний цаадах өрөөнд лав жүжигчин баймаар нас ахимаг ганган авгай нөхөртэйгөө хамт явж байна. Зүгээр ч үгүй, тэр авгайг нэг кинонд үзсэн шиг санагдав. Мөн бусад өрөөнд ч гэсэн хариуцлагатай ажилтан нарт байдаг цэрэг цамц, бариу шуумагт өмд, савхин гутал энэ тэр өмссөнийг үзэхүл магадгүй ардын комиссар буюу тэдний орлогч нар явж байгаа бололтой. Гэтэл вагоны үйлчлэгч, зууш, дарс түгээгч, вагон ресторанд хоол идэх хүнийг бүртгэх гэж ирсэн зөөгч, тэнд очсон хойно хоол зөөгч, буфетны худалдагч энэ тэр цөмөөрөө Костяд гойд уриалгахан хандацгаах ажээ. Костяг энд яваа хүмүүсээс шууд ангилж үзэхээр өөр үггүй болгосон аль нэг юм түүний дүр, байж байгаа царайнаас илт мэдэгдсэн бололтой.

Костя үйлчилгээний бүх хүнтэй чи би гэлцэн дэндүү хээгүй загнаж байх шиг санагдан, Варя эхний үес тун эвгүйрхсэн боловч цаадуул нь мань хүнийг өөрсөдтэйгөө нэг зиндааны улс гэж гадарлаж байгаа бололтой түүний үгэнд гоморхох хүн нэг ч байхгүй, тоглоом хийхэд нь инээж хөхрөн, хэлсэн шаардсан болгоныг нь илт дуртай биелүүлцгээх ажээ. Костя зөөгч нар мэрийн хичээж буйд талархан инээмсэглэж оргилдоо хүртэл мандаж яваа хүнийг хүмүүс тойрон шохоорхдогийг ойлгодог хүний дүр гаргана. Гэхдээ нөхөрсөг хөгжүүн байлаа.

Костяд хэргэм зэрэг, албан тушаал, алдар цолын аль нь ч байхгүй, гэхдээ мань хүнд тийм юмны хэрэгцээ байсангүй. Тэрээр аз турших зантай, хэнээс ч хамаардаггүй, нүдэнд дулаахан эр бөгөөд бусдын дөнгөдөггүй юмсыг л дөнгөдөг хүн. Амралтын ид үе эхэлсэн зургаан сард Крым рүү галт тэрэг яг явах өдөр нь, зүгээр ч үгүй дээд зиндааны хүмүүст нөөцөлсөн олон улсын вагонд суух билет хэн олж чадахсан билээ? Гэтэл Костя чадсан. Билетийн үнийг хоёр, гурав дахин нугалж төлсөн байж болох юм гэж Варя бодсон хэдий боловч ямар ч байсан суудал олсон л байна. Тэрээр үйлчлэгчдийн гарыг элбэг дэлбэг цайлгаж, мөнгөний хариултаа ч буцааж авахыг мэдэхгүй, олз омгоо олон түмэнтэй ингэж хуваадаг ажээ.

Варятай харьцахдаа энэ хоёр нэг насны танил, тэгэхлээр тусгай өрөөнд хоёулхнаа явж байгаад ер хүн гайхах юм байхгүй гэсэн царайтай явна. Бүсгүйн тухай бүх юмыг мэдэх юм шиг түүнээс юу ч эс асууна, бас цаадах нь өөрийнх нь тухай бүхнийг мэдэх юм шиг өөрийнхөө тухай ч юу ч эс ярина. Зам зуурын газар нутгийг ярьж өгч байгааг үзэхүл үүгээр нэг бус удаа явж байгаа нь андашгүй. Оролдож зовоохгүй байв. Энэ хооронд тэврэх, үнсэх мэтээр нөгөөхөө эхлэх гэж ноцсонгүй. Харин хонгилд цонхоор хараад цуг зогсож байхдаа л зөвхөн өрөөсөн гараа мөрөн дээгүүр нь тавьсан, энэ бол зүй ёсны ердийн зүйл, шинэхэн ханилсан амрагууд хонгилд зогсож байгаа хэрэг, тэгээд залуухан нөхөр нь залуухан гэргийнхээ мөрөн дээр гараа тавиа л биз. Ер нь тэр вагоныхан мань хоёрыг шинэхэн хос гэгцгээж байгаа бололтой инээмсэглэн тал өгцгөөж түүгээр ч барахгүй тэр хоёроор, ялангуяа өөрөөр нь нүдээ баясган хужирлаж байх шиг Варяд санагдана. Ийнхүү авгайг цөмөөрөө бахдан харцгааж бүхийд Костя бах нь ханаж тун маадгар байгаа нь Варяд илт байв.

Гагцхүү шөнө юу болдог бол гэхээс л санаа зовно. Бүсгүй өөртэй нь цуг явахыг зөвшөөрнө

гэдэг бол бас цаадхыг нь зөвшөөрсөн хэрэг гэдэгт Костя бас итгэж байгаа нь мэдээж. Ер нь харчуул бүсгүй хүнийг театр, кино, бүжигт урьсан бол хэзээний тэгэх эрхтэй болчихсон гэж үздэг, хэрвээ түүнийг нь зөвшөөрөхгүй бол гомдож уурлацгаана. Гэтэл мань хүн бол түүнийг Крым рүү авч явж байна, тэр хоёр зочид буудлын нэг өрөөнд сууж, түүний мөнгөөр идэж уух болно... Үгүй ээ, ийм наймаа хэрхэвч таарахгүй, өөрөө л лав ийм наймаа хийхгүй. Ямар гүйж түүж, зүүгдэж наалдсан биш. Түүнийг Крым явья гэж гуйхлаар нь л тийшээ явахыг зөвшөөрч чухамхүү түүний төлөө л явж байгаа, зөвхөн тийшээ явахыг л зөвшөөрснөөс биш өөр ямар ч юманд ам өчиг өгөөгүй. Мань хүнд Крымээр залуухан хөөрхөн бүсгүйтэй зугаалахад таатай байх биз, тэр хэрийн хариу бол өгч бололгүй яахав.

Гадаа бүрий орж эхэллээ. Костя нүд рүү нь эгцлэн харж,

–Бүх юм дажгүй биз? хэмээн инээмсэглэв.

–Бүх юм дажгүй ээ гэж Варя аясыг нь дагуулан хариулсан боловч үдэш ойртохын хэрээр айж эмээх нь нэмэгдээд байв.

Хэрвээ Костяд ухаан жолоогүй дурлаж сэтгэл алдсан бол ч яая гэхэв. Гэтэл ухаан жолоо алдсан юм ер алга, алдах ч юм уу, үгүй ч юм уу, бүү мэд. Костягийн бэлжүү сэргэлэн зан бусдын адил өөрт нь ч гэсэн аятайхан санагдаж байгаа, гэхдээ өөрөө бол даруухан байдалд дассан билээ. Костя аль нэг харь орчлонгийн хүмүүжээгүй хүн. Варя өөрөө бол хэдийгээр гудамж хороогоор өсөж бойжсон ч гэсэн зөв хүмүүжилтэй. Найз нөхөд нь ч бас хүмүүжилтэй. Лёвочка, Ика, Рина, Том Воля, Бага Воля энэ тэр цөм боловсон залуус, харин Костя бол хэдийгээр тэдний толгойлогч ч гэсэн боловсон бус хүн. Цаадуул нь түүнийг бараадаад байдгийн учир бол өөрсдөд нь байхгүй нэг юм түүнд байгаа учраас тэр. Тэр юм нь мөнгө. Мань хүн тэдгээр залуугаар өөрийгөө хүрээлүүлж байгаагийн учир бол өөрт нь байхгүй нэг юм тэдэнд байгаа учраас тэр. Тэр юм нь боловсон зан. Мань хүн ард түмний дундаас, орон нутгийн гүнээс гаралтай хүн, тийм араншин, тийм төрхтэй, түүнийг гагцхүү тэгж л тусгаж авч болно. Гэхдээ энэ бүхэн Варягийн санаанд бүрэн нийцэхгүй байна.

Харин түүний биеэ даасан байдал сэтгэлд нь нийцэж байна. Мань хүний өөрийнх нь хувьд гэвэл гагцхүү амиа тэжээх цалингаа өөрөө олж гэмээж нь л сая биеэ даасан байдалтай болно. Энүүний авгай боллоо ч гэсэн гагцхүү тэгж байж л биеэ даах болно. Гэхдээ энүүний авгай болох санаа бий билүү, үүнийг өөрөө бас л мэдэхгүй байгаа. Гэрлэх тухай тэр хоёрын хооронд ямар ч яриа хөөрөө байгаагүй. Тэгвэл түүний нууц амраг болох хэрэг үү? Гэтэл нууц амрагууд чинь бие биедээ хайртай шүү дээ. Тэгвэл энүүнээр тэжээлгэдэг хүүхэн болох уу? Үгүй ээ, хүнээр тэжээлгэх бодол зорилго түүнд байхгүй.

Гэвч Варя өөртөө юу гэж ч ярилаа гэсэн өөрийнх нь бясалгал үнэмшил муутай байгааг ойлгож байв. Болох ёстой юм болохоо л нэг болно. Худлаа маяглана гэдэг бол худлаа жүжиглэсэн хэрэг болно.

Дворец тосгонд тэд нар нөгөө завьчин, түүний үг цөөтэй авгай хоёроос салав. Нил Лаврентьевич шуудан руу гүйж очиж хүлээн авагчийг дагуулж ирээд завинаас шуудайтай юмнуудыг гаргалцаж, Саша, Борис хоёрыг огтхон ч тоохгүй ажлаа эмхлэн, тайлбар тавьж байв. Зам нь таарсан цөллөгийнхнийг авчирлаа, тэгж тушаасан юм, тэгээд л авчирлаа гэсэн янзтай.

–Комендантын газар орцгоох юм уу? гэж Борис санал хэлэв.

–Яах гэж?

–Кежма явуулна биз.

–Тэдэнтэй тэдэнгүй хүрэх газраа хүрцгээнэ. Дагавар бичиг бидэнд байгаа юм чинь.

–Яагаад ирээгүй, яагаад тэмдэглүүлээгүй вэ гэж тусгүй юм болж магадгүй, яльгүй юмаар тэдний дургүйг хүргэх хэрэг алга гэж Борис нүүрээ үрчийлгэв.

Саша комендантын газар луу очмооргүй байв. Илүү уулзлаа гээд илүү доромжлуулахаас өөр юм байхгүй. Борисын толгойд гагцхүү Фрида байгаа учраас бушуухан түүний тухай хөөцөлдөх зориг эрмэлзэл дүүрэн байжээ. Дворец тосгон районы төв болно гэдгийг дуулчихаад хожим Фридаг өөр лүүгээ аваачих эсвэл өөрөө Фрида руу очих ажлыг хөнгөвчлөхийн тулд энд ямар нэгэн танилтай болж холбоо тогтоохыг санаархжээ. Зөгнөдөг эр шүү.

–Маргааш шийдье гэж Саша хэлэв.

–За яахав хэмээн Борис зөвшөөрөөд, –Юмаа хараад сууж байгаарай, би байр хайя гэв.

Нар үүлний цаагуур далд орж голын зүгээс хүйтэн салхи сэнгэнэн эрэг дээрх туяхан бургасыг найгуулна. Саша пальтоогоо мөрөн дээрээ тохоод чемоданаа авчрав. Сэтгэл ганихран өр шимширнэ. Мань эр яагаад комендантын газар луу очсонгүй вэ? Квачазе бол очоод л шаардлага тавих байсан, бас Борис ч очих санаатай, тийшээ очиж ажил явдлаа зохицуулахыг хүсэж байна, тэр чинь түүний эрх шүү дээ. Гэтэл мань хүн тийшээ явсангүй, явах ч үгүй. Аглаг зэлүүд мөрнөөр харуул хамгаалалтгүй долоо хоног явах зуур тэрээр эрхбиш бага ч гэсэн чөлөөт байдлыг мэдэрчээ. Гэтэл тэр нь ингээд дууслаа гэж үү? Энд, орчлонгийн зах хязгаар энэ нутагт эрх чөлөөгүй байна гэдэг бол гойд ёс бус, гойд мунхаг хэрэг. Үгүй дээ, заяа нь тийшээ очихгүй. Өөрийгөө хуурч, сэтгэлээ хий зогоож байгаа бол тэр л биз!

Борис эргэж ирээд хөгжүүн дуугаар,

–Би таныг одоо их эзэнт улсын хэлтэрхийтэй танилцуулъя. Их хааны тогооч! Юсупов ноён, Григорий Распутин энэ тэрийг хооллож байсан хүн. Гайхам хосгүй амьтан! гэж өгүүлэв.

Мань хүний Сашаг дагуулж ирсэн модон байшинд газар өнгийн хавмал хөвөнтэй хүрэмтэй,

мөн хавмал өмднийхөө шулханагийг түрийг нь ярсан савхин гуталд чихэж өмссөн улаан хамартай түнтгэр өвгөн урт сандал дээр сууж байв. Сахлыг нь мөлчийтөл хуссан сэлхэгэрдүү царай, хөвд шиг жигдхэн хөвсгөр цагаан үс энэ тэрийг харахул мань өвгөнийг хотын хүн гэлтэй.

–Танилцаарай, Антон Семёнович гэдэг хүн! Их эзэн хааны ордны тэргүүн цавчин хэмээн Борис догдлон өгүүлэв.

–Тэгж яривал манлай цавчин гэх байлгүй хэмээгээд Саша өвгөнийг сониучирхан ажиглав.

Цаадах нь ч гэсэн дутуу аньсан нүдээрээ Сашаг анхааралтай сонжин харлаа.

–Антон Семёновичийг Москва руу эгүүлэн дуудаж байгаа гэнэ, элчин сайд, элчин нарыг дайлж байх юм байх. Далайн чанадын нарийн хоол хийгээд л... Би Москвад яггүй тогооч нарыг мэддэг байсан юм. Таны зиндаанд яаж хавирах билээ, гэхдээ гайгүй улс үлдсэн шүү. “Гранд-отелийн” Иван Кузьмич гэж бий, таних уу? гэж Борис асуув.

–Санаанд орохгүй байх чинь нь хэмээн Антон Семёнович өөрөө аль нэг Иван Кузьмич болгоныг санаж байх албагүй, харин аль ч Иван Кузьмич мань Антон Семёновичийг бол мэдэж байх ёстой гэсэн шиг хайхрамжгүй хариулав.

–Тун дажгүй тогооч шүү, мэдээж, хоол хийх юм нь байж гэмээж нь. Альберт Карлович гэж бий.

–Танина гэж Антон Семёнович товчхон өгүүлэв. Борис дундын танил хүн гарч ирсэнд олзуурхан сэргэж,

–Мэргэжил сайтай, нүүр дүүрэн эр шүү гэв.

–Юугаараа ч нүүрлэх юм билээ дээ хэмээн Антон Семёнович хямсйн өгүүлээд, –Нэг, хоёр, гуравдугаар... гэв.

–Харин тэрийг чинь л хэлж байна хэмээн Борис өлгөн авч, –Хийх юм нь л байдаг юм бол ч. Бас хийлгэх хүн нь байдаг юм бол. Нарийн махан хуурга ч мөн ванлий... гэв.

–Нарийн махан хуургыг ч гэсэн хийж чаддаг байх ёстой гээд Антон Семёнович оройн хоол хийж суугаа гэрийн эзэгтэй рүү эргэж харав.

–Та хэзээ явах юм бэ? гэж Борис асуув.

–Тавингуут нь л явна.

–Суллагдсан бичгээ авчихсан гэж та ярьсан биз дээ.

–Би комендантын газар ажиллаж байгаа. Тэд нар бас хоолонд дуртай, тэгээд хойш нь чангаагаад байгаа юм.

Гэрийн эзэгтэй загасаа цэвэрлээд хайруулын таваг руу хаяв.

Борис пийшин рүү дохиж,

–Та хийвэл ямархан болохыг төсөөлж байна гэв.

Антон Семёнович дүнхийгээд дуугүй өнгөрөв.

–Москвэд эргэж очсон хойно та биднийг нэг сайн дайлна шүү хэмээн Борис инээв.

Антон Семёнович түүн рүү хялайснаа архичин хүний муйхар зангаар,

–Юм олуулбал одоо л олуул гэж хэлэв.

Тэгээд Борисоос мөнгө авч арайхийн босоод гадагшаа гарлаа.

–Архичин гэж Саша өгүүлэв.

–Биш, хүний мөрөөсөл болчихсон амьтан гэж Борис хэллээ.

Антон Семёнович шил спирттэй буцаж ирэв.

–Яг хэрэгтэй юм энэ. Зүрхний тухайд тэр шүү.

Өвгөн бараг юм идэхгүй ууж байгаад дорхноо согтчихов. Хүзүү нь хүрээнтэн, муухай царайлаад, хүний мөнгөөр уух мөртөө уухгүй, тэр хүнээ зүхэх санаатай байгаа бололтой. Борис ингэж байгааг нь анзаарахгүй Москвагийн танил тогооч, ахлах үйлчлэгч нарыг тоочсоор байв.

–Та ямар хэргийн учир энд ирээ вэ? гэж Саша асуув.

Антон Семёнович энэ санамсаргүй таарсан архины найзууд, юуны өмнө хүнд туйлын амархан маллуулдгаас нь болж үзэн яддаг Москвагийн энэ тэнэг банди нарыг зүхлийн муугаар зүхэх санаатай Саша руу хөлчүү харцаар ширтэв.

Гэтэл Москвагийн тэнэг банди нарын хүний ая дагасан харц биш, бүхний учрыг мэддэг, хэнд ч гэсэн зохих хариуг нь өгч чаддаг Москвагийн гудамжныхны доогтой харцтай мөргөлдөв.

Антон Семёнович гөлөр харцаа буруулан амьсгаадаж, дурамжхан гэгч нь ийн ярив.

–Нэг районы гуанзанд ажиллаж байсан юм. Тэгээд хоолныхоо цэсэнд “Залхуутай шөл” оруулчихлаа. Гэтэл прокурор “Яагаад залхуутай” гэж байгаа билээ? Гавшгайчуудыг дооглож байгаа юм уу гээд ноцчих нь тэр. Мянга есөн зуун гучин онд гарсан хоолны тухай номоо үзүүлж “Залхуутай шөл” гэж байдгийг харууллаа. Мэдэв үү? Үгүй ээ, худлаа ярьж байна! Энэ номыг чинь бас эсэргүү бичсэн байна гэдэг байгаа даа.

Сашагийн энэ зуур сонссон хэрэгнүүдээс хамгийн утгагүй нь энэ байв.

–Одоо бүх юм дууссан хойно яамай. Та ялаа эдэлж дуусаад одоо гэртээ буцаж байна шүү дээ гэж Борис өрөвчхөн өгүүлэв.

–Гэртээ гэнэ үү?! хэмээн Антон Семёнович Борис руу муухай харж, –Хаа байгаа юм бэ, тэр гэр чинь? Еврейчүүдийн үүр болсон Бердичев хотод уу?

Үгүй ер! Ямар нь мэдэгдэхгүй хүн болгонтой наалдаад байх хэрэггүй гэдгийг Борист сануулсан сургамжтай юм болж байна.

–Аль вэ, эндээс тонил, үхэж хатаж байх нь таарсан хүний адаг минь! гэж Саша хэллээ.

–Үгүй, тэгэхгүй шүү! гээд Борис үүд рүү очиж хаалганы цүүг хийлээ.

–Хүүе хүүхдүүд ээ, та нар яачихав? Би зүгээр л тоглосон юм гэж Антон Семёнович сандрэн гүвтнэв.

–Сүүлчийн удаа тоглох чинь энэ дээ, муу шулам гэж Саша тамшаалав.

Борис Антон Семёновичийг дарж авч толгойг нь ширээ рүү няхлаа.

Антон Семёнович өөдгүй цэхэр нүдээ бүлтэлзүүлэн,

–Хүүхдүүд ээ, тавиач дээ хэмээн сөөнгөтөв.

–Боря, битгий дуусгачихаарай, миний хувийг үлдээнэ шүү гэж Саша хэлэв.

Энэ цэхэр нүдтэй сэлхэн нүүртийг мань хүн харахаас дургүй хүрч байжээ. Муу зовлого! Хүн элэг барих санаатай гэнэ! Хорт могой! Муу сэг! Зовлон нэгт нөхөр гэж байгаа нь энэ! Хань гэнэ!

Зодолдохдоо хүрч ийм муухай юм болох гэж байх уу даа, гэвч амьдралын ёроолд тунасан ийм шаарнуудыг ингэхээс өөр арга байхгүй.

–Муу могой минь, өршөөл гуй!

–Училж үзээрэй хэмээн Антон Семёнович шуухитнав.

–Одоо тэгвэл чөтгөр шулам руугаа тонил! Борис түүнийг хаалгаар түлхэн гаргаж довжоон дээрээс авч хаяад урт сандал дээр лагхийтэл суулаа.

–Нөгөө эзэн хааны манлай цавчин гэдэг чинь энэ дээ хэмээн Саша инээд алдав.

–Фрида ийм хүмүүсийн дунд амьдрах ёстой болчихоод байгаа юм гэж Борис өгүүлэв.

Тэр хоёр маргааш нь зам нийлэх завьтай таарлаа. Нэг хоршоочин, завьчин хоёр завинаас нь яг өөрсөдтэй нь адилхан таталцаж явна гэвэл тэднийг авч явахаар болов. Кежма хүртэл далан километрийн зайтай, хэрвээ ямар нэгэн саад тохиолдохгүй бол тэр хэд хоёр хоногт багтаад

хүрчихнэ. Энэ бол азтай хэрэг байлаа.

Тэр хоёр юмаа эрэг рүү аваачиж, тэдний гол өгсүүлэн чирэх гэж байгаа их ачаатай том завь руу дөхүүлэв. Завины дэргэд нөгөө хоршоочин гэж бэржээнтэн цувгай, намгийн урт түрийт шиг хэрнээ бугын шилбэний арьсаар хийсэн олонгодой гуталтай, минчгэр царайтай хөгжилтэй эр юм янзалж байв.

–Мөд явах уу? гэж Борис асуув.

–Бичиг сачгаа бүрдүүлчихээд л хөдөлнө дөө гэж хоршоочин хариулав.

Борис Сашаг хажуу тийш аваачиж,

–Саша, хоёулаа ямар ч атугай комендантын газраар очъё. Завь тааралдаж юмаа аччихаад, бушуухан бүртгүүлээд гарахаар ирлээ гэж хэлье. Тэгэхгүй бол Кежмад очсон хойно тусгүй юм болно. Нөгөө эзэн хааны тогооч гэдэг шулам чинь биднийг энд байна гээд хэзээний хошуу өргөчихсөн байгаа гэв.

–Та очиж болно энэ бол таны хэрэг, харин би бол очихгүй. Намайг энд явна гэдгийг битгий хэлээрэй. Би Кежмад очих тушаалтай, тийшээ л очсон байх болно гэж Саша тоомсоргүй өгүүлэв.

–Дураараа бол доо хэмээн Борис дал мөрөө хавчаад –Би ямар ч байсан очлоо гэв.

Мань эр зүгээр байж чадахгүй дон нөхцөөд байгаа хүн. Фридатай суух хүсэлдээ хөтлөгдөн, саад болох ямар нэгэн алдаа гаргачих вий хэмээн бүх юмаа түүнтэй холбон бодож байгаа юм.

Борис хагас цаг битгий хэл бүтэн цагийн дараа ч эргэж ирсэнгүй. Хоршоочин бичиг баримтаа бүрдүүлэх гэж яваад хэдийн эргээд ирчихсэн байхад мань хүн байдаггүй.

–Чи явж нөхрөө хай, цаг алга шүү, орхиод л явцгаахаас гэж хоршоочин хэлэв.

Саша яахаа мэддэггүй. Борисыг орхиж болохгүй, гэтэл комендантын газар очмооргүй байдаг, нөгөөтэйгүүр одоо бас оройтчихсон, яагаад шууд ирээгүй вэ? гэж шалгаана.

–Дахиад жаахан хүлээцгээе.

Тэгж тэгж Борис сая нэг юм ирж чемоданаа завин дээрээс үг дуугүй суга татаж авав.

Саша юу болсныг гадарласан ч гэсэн,

–Юу болоо вэ? гэж асуув.

–Намайг Рожково руу яв гэж байна гэж Борис хариулав. Царай нь танигдахын аргагүй болчихжээ.

Голын зүүн эрэгт байдаг Рожково гэдэг бяцхан гацааг тэд нар өчигдөр Нил Лаврентьевичтэй

явж байхдаа дайрч өнгөрсөн билээ.

–Районы бүрэн эрхт төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр үү?

–Эд нар суух газрыг өөрснөө тогтоох эрхтэй юм гэнэ.

–Тэднийг бүү тоо, цуг явцгаая.

–Миний тушаалыг тэд авчихсан.

Борисын хоолой чичирч байв.

–Гутраад яахав. Рожковод очингуугаа Кежма,

Канск хоёрын аль нэг рүү захиа бичиж шилжүүлж авахыг шаардах хэрэгтэй. Рожковод танд таарах ажил байхгүй юм чинь. Би Кежмад очсон хойноо тэндхийн бүрэн эрхт төлөөлөгчид бас хэлье гэж Саша зөвлөв.

Борис гараа савлан хаяж,

–Нэгмөсөн баларлаа! Би мөн тэнэг толгой шүү! гэв.

Борис бол замд цуг явахад гутардаггүй, хөгжилтэй сайн нөхөр. Тэгж бодохоос Саша түүнийг өрөвдөж түүнээс хагацна гэхэд гунигтай байв. Тэр хоёр тэврэлдэн бие биеэ үнсэцгээлээ. Борисын нүдэнд нулимс гялалзав.

Саша завин дээр гарлаа. Завьчин завиа эргээс түлхэж хөдөлгөөд ирмэг дээгүүр нь бөгтрөн давж завь руугаа орлоо. Эрэг дагуу байгаа олон завь, тор энэ тэр завиа татаж явахад саад болох учир тэд нар нэг хэсэгтээ сэлүүрдэн явцгаав. Саша гутран зогсож буй Борисыг харлаа. Цаадах нь араас нь харан зогсож байснаа чемоданаа аваад дэнж өөд өгсөв.

Саша эл хуль голоор ирээдүйгээ зорин ганцаараа явж байна. Сайн мууг бүү мэд, ямар ч атугай бусад нь бүгдээрээ байх суух газраа тогтоолгочихсон байхад мань хүн өөрийг нь чухам юу хүлээж байгаа, хааш нь явуулахыг мэдэхгүй байна. Тэрээр Квачазе, Ивашкин хоёр болон замын тосгонуудад тааралдсан цөллөгийнхөнтэй дахиад хэзээ ч таарахгүй, мөн нэг районы дэвсгэрт байх хэрнээ Бористой бас тааралдахгүй байх. Эхний хэдэн зуун километр замыг цуг туулсан хүмүүсээсээ хагацан саллаа гэж бодохоос өр зүрх гөхөлзөн шимшрэв.

Завьчин гэж зэрлэг танхай царайтай дөч эргэм насны ярих дургүй эр завины хошуун дээр сууж явна. Саша хоршоочинтой ээлжлэн хударганд орж, харгиа таарсан үед хоёулаа хамтран чангаана.

Цэргээс халагдаж ирээд байгаа хүнтэй нийтлэг зантай залуу хоршоочныг Федя гэх агаад Кежмагийн ойролцоох Мозгова сууринд худалдагч хийдэг гээд өөрийгөө тосгоны дэлгүүрийн эрхлэгч хэмээн дөвийлгөнө. Красноярскт нэг курст суухаар бургтүүлсэн учир тийшээ ном үзэхээр өвлөөс явах ажээ. Тэрээр хөдөөгийн худалдагч тосгонд улсын бодлогыг явуулагчийн хувьд ямар үүрэгтэй байдаг тухай элэг авмаар дээгүүр юм ярина. Хөдөөгийн идэвхтний шинэхэн дүр энэ. Юмны учир олохдоо сэргэлэн, аль ч юмыг эргэлзэх, тунгаан бодох гэж байхгүй шууд бэлэн зэлэн үнэмшин хүлээж авдаг, нэмэрт нь дуучин, хөгжимчин эр. Саша цөллөгийн хүн гэдэг нь мань эрийн хувьд ёстой падгүй хэрэг байж. Цөллөгийнхөн байна гэдэг бол ийм л байх ёстой хэрэг, үеийн үед л ийм байсан, цөллөгийнх ч гэсэн яг л бусдын адил хүн шиг л хүн байдаг. Хэрэв Федя комендантын газрын салаанд цэрэг байж байгаад мань хүнд Сашаг буудан алах тушаал өгсөн бол буудчих л байсан. Яагаад тэр вэ гэхлээр орчлон ийм л байх ёстой хэрэг.

Федя Сашагаас Москвагийн тухай асууж ямар гудамжинд сууж байсан, тэр нь хэр зэрэг сайхан гудамж болох, өөр ямар ямар гудамж байдаг, эцэг эх нь юу хийдэг, Кремльд ер нь орж үзсэн эсэх, нөхөр Сталин болон бусад удирдагчийг харсан эсэх, дэлгүүрт бараа таваарын үнэ ямар байдаг энэ тэрийг шалгаав. Хэлсэн болгоныг гайхаж бахдах ажээ. Түүний мөрөөдлийн цаад үзүүр Москва юмсанж. Жинхэнэ Москвагийн хүн! хэмээн Сашаг бас бахдаж байв. Тэгээд районы удирдлагад зориулсан “Люкс” тамхиараа түүнийг дайлав.

Мань хүн цөллөгийнхний Ангарад авчран түгээсэн “Мартагдсан хаягдсан” гэдэг дууг заримдаа аялна. Сайхан дуулж байна! “Миний булшин дээр мэдвээс хэн ч ирэхгүй, харин хавар эртээр гургалдай нэгэнтээ донгодно, донгодож жиргэчихээд нисэн одно, өнчин булш минь тэр л янзаараа хоцорно”.

Одоо тийм заншилгүй болсон учраас Федя алтны уурхайд яваагүй ажээ. Харин цэрэгт явахынхаа өмнө профессор Куликийн ангид алба хааж тунгусын солироос хайлцсан боловч юу ч олоогүй, бодвол газар доошоо шигдээд орчихсон юм байгаа биз. Тэр ормон дээр нь нуур үүсэж, хожим намагширсан тул ялаа шумуул барьж идчих гээд ямар ч аврал байхгүй, амьтай голтой хэн боловч зайлахын түүс, Федя ч гэсэн хугацаат цэргийн албанд дуудагдсаныг ч хэлэх үү, тэндээс уухайн тас зугтжээ. Энэ нутагт хорин зургаан оноос эхэлж цэрэгт татах болсон, бас хорин зургаан оноос сургууль байгуулагдсан, түүнээс өмнө сургууль байгаагүй, нутгийн

хөвгүүдээс ганц бичиг үсэгтэй нь мань хүн, бэлтгэлийн газар ажил хийж, хамнигануудтай наймаа хийдэг байсан эцэг нь бичиг зааж өгсөн юмсанж.

Федя хамнигануудын тухай,

–Ямар ч боловсролгүй, зэрлэг бүдүүлэг ардууд. Гэхдээ тэднийд хулгай байна гэсэн ном байхгүй хэмээн цайлган сэтгэлээр ярьж –Орос хүнийг Петрушка, Ивашка, Павлушка, Корнилка гэхчлэн нэрлэнэ... “Манай гурил өгөв өө”, “Жаахан жаахан харсан хэрэгтэй”, “Хоёр талх зарав аа”... Тамхинд дуртай, эр эм ялгаагүй тамхи татаж, архи ууна, хувцаслах нь ч гэсэн эр эм гэж ялгарах юм байхгүй. Харин хүүхдийг бол ялгаж болно, банди нар нэг салаа гээгтэй, охид нь хоёр салаа гээгтэй. Өлбөнд учиргүй дуртай, дээлэндээ ч хадна, камасины гуталдаа ч хадна.

“Камус” гэж хамниганаар буга буюу хандгайн шилбэний арьсыг хэлдэг, тэгээд түүгээрээ гутал хийгээд түүнийгээ камасины гэдэг юм. Энэ үг индианчуудын мокасины (тэднийхний зөөлөн гутал) гэдэг үгтэй төстэй байгаад Саша ихэд гайхав. Энэ бол хамниганууд Хойт Америкийн индианчуудтай нэгэн омгийнх гэдгийг нотолж буй баримт.

Ийшээ орон нутгийн хэлний аялгуу судлахаар хайгуулын ангитай хамт ирэх буюу геологийнхантай ирэх юмсан, энэ газарт ч ёстой тоо томшгүй баялаг бий дээ. Гэтэл мань хүн бөглүү тосгонд тэндээс гарч явах ч эрхгүй цөлөгдөж, гурван жил өөрт ч ашиггүй, өрөөлд ч нэмэргүй тэнгэр тортогтуулах хувь ноогджээ.

Яагаад ийм гай түүнийг нөмөрч авав аа? Мань эр өөрөө буруутай юм биш үү? Криворучкогийн тухай хэлчихсэн бол одоо эрх чөлөөтэй байх байсан. Гэтэл ёс суртахуунд харш гэж санаад хэлээгүй. Ингэхэд... ёс суртахуун гэдэг чинь юу вэ? Пролетарийн ашиг сонирхолд нийцэж байгаа юм бүхэн ёс суртахуунд таарна гэж Ленин ярьдаг байсан.

Гэтэл пролетари гэдэг чинь хүмүүс, тэгэхлээр пролетарийн зан суртахуун гэдэг бол хүний зан суртахуун. Тэгвэл хүүхдүүдийг цасан дотор орхино гэдэг бол хүний ёсноос гадуур зүйл, тэгэхлээр ёс суртахуунд харшилна. Тийм учраас бусдын амьдралыг золионд гаргаж өөрийнхийгөө аварна гэдэг бол бас ёс суртахуунд харш.

Тургенев гэдэг санаанд оромгүй нэртэй арал дээрх Заимка тосгонд сүүлчийн хоногоо хоноглов. Энэ арлын урт хорин хоёр километр, доод үзүүрт нь Алёшкино тосгон, дээд үзүүрт нь Заимка байдаг ажээ.

Сашаг оруулсан модон байшин хэд хэдэн пүнз савтай, хашаан дотроо банз дэвссэн, цэлгэр том байшин аж. Тэр айлд гэрийн эзэгтэй гэж залуудаа сайхан хүүхэн явсан бололтой толиотой нүсэр авгай, гэрийн эзэн гэж шар толгойтой авиралдсан үрчгэр өвгөн, хүүхдүүд нь гэж том нь дөч шахаж яваа, бага нь гуч эргэм насны бүргэд хамартай өтгөн хөмсөгтэй жинхэнэ кавказынхан гэлтэй хар толгойтой цахилсан нүдтэй гурван хархүү бас тэдний авгай хүүхдүүд байцгаав.

–Одоо Василий багш ирнэ, тэгэхээр оройн зоог цуг барьцгаагаарай гэж эзэгтэй өгүүлэв.

Борооны цув, савхин гуталтай, эрүүндээ хүрэн халиун сахалтай, зурмал бурхны номхон дүрстэй санваартан ирж гэрийн жанчаа өмсөв. Гэрийн эзэгтэй борцолсон загас, шарсан өндөг, сүү энэ тэрээ ширээ рүү тавилаа. Василий багш юм идэх зуур Сашагаас хаанаас хаа хүрч яваа, хаана төрсөн, эцэг эх нь хэн болох зэргийг асуув. Өөрөө бас цөллөгийн хүн гэдгээ хэлэв. Харин Сашаг юуны учир цөлөгдсөнийг асуусангүй, бас өөрийнхөө тухай ч хуучилсангүй.

Оройн хоолны дараа тэр хоёр Василий багшийн ор, нэг авсаархан ширээ бүхий бяцхан пин рүү очицгоов. Сүмэрхүү яльгүй эвгүй үнэртэй ажээ.

–Тайчаад хөлөө жигнэчих, сайхан болно шүү гэж Василий багш хэлээд тогоо халуун ус түмпэнтэй авчирч бас саван, нүүр гарын алчууртай өгөв. Саша хөлөө халуун усанд хиймэгц тэр даруй бие сульдан тавирч, алжаал замхран одохын жаргалыг эдэлж эхлэх нь тэр.

Василий багш хатавч түшээд Сашаг дөлгөөхөн харцаар харж байв. Саша түүнийг одоо тогтож харсанд тун залуухан хүн гэмээр ажээ. Эхлээд харахад сахалтай бас жанчтай болоод ч тэр үү, санваартан болоод ч тэр үү ахимаг юм шиг санагдсан билээ. Ер нь ч Саша лам хүнийг өвгөн байх ёстой гэж төсөөлдөг байжээ. Аливаа санваартан хүн хувьсгалын өмнөөс л тийм байсан юм шиг мань хүнд санагдана.

–Халуун усыг галласан ч болох л доо. Даанч голын эрэг дээр байдаг болохоор та буцаж ирэхдээ салхи авчихна, цаашаа явах хүн яаж болох вэ гэж Василий багш хэлэв.

–Ингээд байхад ч сайхан байна, гялайлаа гэж Саша хариулав.

–Энд ч задгай л угаацгаадаг юм, танай Москвад бодвол онгоцтой биз дээ? гэж Василий багш асуув.

–Бий, онгоцтой шүү.

–Манай нутагт бас пийшинтэй халуун усны газар байдаг юм, эсвэл зүгээр л пийшин дээрээ гараад угаачихна. Эндхийн улс хавьгүй цэвэрч юм.

–Та хааныхн хүн бэ? гэж Саша асуув.

–Рязань мужийнх, Кораблийн район, дуулсан уу?

–Рязань мужийг мэднэ, харин Кораблийн районыг мэдэхгүй.

–Манай нутаг ч өмнө зүгийн алимын орон шүү хэмээн Василий багш инээмсэглэн өгүүлж, – Та энд алим, лийр алийг нь ч үзэхгүй, жимсээ санана даа, аньс, хад, нэрс гээд эндхийн хамаг жимсгэнэ гүйцэх нь тэр, за яахав лавцаг, бас ойн жижигхэн үхрийн нүд бий. Харин жимс бол юу ч байхгүй гэв.

Саша халуун усан дотор хөлийнхөө хурууг хөдөлгөн тухалж,

–Жимсгүй аргалах л хэрэг болж дээ гэв.

–Та наадхаа саванд, савандаад угаа л даа, аль вэ би савандаад өгье гээд Василий багш саван, үрүүл хоёр авав.

–Юу гэсэн үг вэ, хэрэггүй, би өөрөө савандчихна! хэмээн Саша бүр айж орхив.

Гэтэл Василий багш аль хэдийн үрүүлээ усанд дүрж хөөсөртөл савандчихсан Саша руу тонгойж ирээд хөлийг нь үрж гарав.

–Хэрэггүй ээ! Та чинь яаж байгаа нь энэ гээч вэ? хэмээн Саша дуу алдан хөлөө салгах гэж оролдохдоо усаа цалгиулж асгахаас бас болгоомжлов.

Василий багш Сашагийн хөлийг зад угаах зуур,

–Зүгээр зүгээр. Танд эвгүй ч гэсэн надад эвтэйхэн байна хэмээн эелдэг дуугаар аргадан өгүүлэв.

–Үгүй үгүй, баярлалаа та минь! хэмээн Саша арайхийж үрүүлийг нь түүнээс салгаж авлаа.

–За, угаа угаа гээд Василий багш гараа арчив.

–Та энд юу хийж байна даа? гэж Саша асуув.

–Ажил хийдэг, энэ айлд бас тус болдог юм, эднийхээр хооллуулж ундлуулж байгаа, баярлахаас өөр юм алга. Тусархуу сайн улс, сайхан сэтгэлээр хандахад хариуд нь мөн ачийг ачлах улс. Удахгүй эндээс цөллөгийнхнийг явуулах байх аа даа.

–Яагаад тэр билээ?

–Хамтралаас болоод тэр. Энд хувийн аж ахуй гэж юм байхгүй, мөнгө олох ажил хаа ч алга, гэтэл цөллөгийнхнийг хамтралд авахгүй юм. Энд хөрөнгөө хураалгасан нударганчууд, тусгай нүүдлийнхний хамтралуудаас бий л дээ, тийш нь ч бас авахгүй байгаа юм...

–Энэ айл черкестэй төстэй хачин хүүхдүүдтэй юм. Василий багш инээмсэглэв.

–Эзэгтэй нь залуудаа нүгэл үйлдчихэж л дээ. Эднийд кавказын нэг цөллөгийн эр сууж байсан юм гэнэ, ёстой сайхан эр гэнэ билээ. Тэгээд л нүгэл тохиолдчихгүй юу.

–Нэг бус удаа тохиолдсон бололтой, гурван хүү байгаа юм чинь гэж Саша өгүүлэв.

–Тэр хүн эднийд есөн жил суусан хэмээн Василий багш уриалгахан тайлбарлаж, –Тэгээд яваад өгсөн гэж байгаа. Хүүхдүүд нь үлдсэн юм байж. Гэрийн эзэн тэднийг өөрийнхөө хүүхэд гэж үздэг, цаадуул нь ч өөрийг нь эцгийгээ гэж үздэг юм байна. Энд хэзээнээсээ нааш цөллөгийнхөн тасардаггүй болохоор хүн ардууд холилдож гүйцжээ. Аятай сайхан амьдарцгаах юм, намайг ч гэсэн харж хандацгааж байна. Эд нарт гойдын шүтлэг байхгүй, ер нь энэ нутагт жинхэнэ шүтлэг хэзээ ч байгаагүй юм. Хэдий Сибирь ч гэсэн сэтгэлд сүжиг хэрэгтэй л дээ.

–Та мөргөл үйлдүүлж байна уу?

–Сүм хаалттай... Зүгээр ярилцаж, хүмүүсийг тайтгаруулах л юм.

Саша хөлөө арчаад оймсоо өмсөв.

–Унтаж амар даа гэж Василий багш хэлэв.

–Түмпэнтэй усаа гаргачихаад хэвтэнэ ээ гэж Саша хариулав.

–Би гаргачихна, та хааш нь асгахыг мэдэхгүй юм чинь гээд Василий багш түмпэнг авлаа.

Дараа нь даавуу авчирч шалаа арчаад тогоог гаргав.

Дахин буцаж ирээд ороо засав.

–Хэвтээрэй!

–Юу? Та өөрөө яах юм бэ?

–Хэвтэх газар олно, би гэртээ байгаа хүн, та хэвт.

–Тэр ёстой ярихгүй! Би шалан дээр хэвтье.

–Шал хүйтэн, та салхи авчихна. Би пийшин дээр унтах дуртай.

–Би ч гэсэн пийшин дээр унтах дуртай гэж Саша зөрөв.

–Эднийхэн хэвтэцгээчихсэн байгаа, тэднийг сандраах хэрэг болно, би бол аятайхан чимээгүй хэвтээд өгнө, хэн ч сонсохгүй гэж Василий багш хариулав.

Тэрээр Сашаг зөөлхөн ятгаж байгаа боловч үүргээ биелүүлэхэд нь юу ч саад болж эс чадах эрс шийдэмгий байдал тэр зөөлхөн зангийн цаанаас илт мэдэгдэнэ. Тэр үүрэг нь энэ тухайд бол өөртөө байгаа юмыг хүнд өгөх үүрэг шүү дээ. Гэтэл мань хүнд түмпэнтэй ус, нарийхан төмөр орноос өөр юу ч алга.

Саша орон дээр хэвтмэгц сэрүүхэн даавууг мэдрэв. Ойр мөдөд цагаан даавуун дээр унтаагүй, ойр мөдөд дулаахан хөнжил нөмрөөгүй юм байна. Нэгэнтээ суниагаад хана руу эргэж зүүрмэглэлээ.

Шоронд байхаас сэргэг унтаж сурсан тул өглөөгүүр юм шүжигнэх чимээнээр сэрэв. Шалан дээр дах дэвсээд үстэй дээлээр хучиж унтсан Василий багш босож байгаа нь тэр байжээ.

–Үгүй тээр хэмээн Саша өндийн орон дээрээ сууж, –Пийшин дээр гарч хэвтэнэ гэсэн чинь яасан билээ? гэв.

–Пийшин рүү гарах гээд зүтгэсэн чинь аль хэзээний эзнээ олчихсон байна билээ. Би энд ч

гэсэн эвтэйхэн аяа олсон, нойроо сайхан авлаа хэмээн Василий багш хөгжилтэй өгүүлэв.

–Та дайрсан хүн болгонд ор дэвсгэрээ өгөөд байх ёсгүй, та бол ганцаараа, дайрах улс олон.

Василий багш хананд өлгөөстэй буй халаасны бяцхан толинд тольдон үсээ самнаж гэзгээ зангидах зуур,

–Хаа байна, тэр олон чинь? Гурван сар ерөөсөө хүн үзэгдсэнгүй. Өдөр болгон ч дайрч өнгөрдөг юм биш, түүнээс гадна айлуудад ээлж тогтоож өгдөг юм. Манай энэ байранд жилд нэг юм уу хоёр удаа л хүн таарна. Би энэ орон дээр шөнө болгон унтдаг юм чинь надад хамаа алга, танд бол муу ч, сайн ч амралт. Унт унт, цаг болоогүй байна гэв.

Тэгээд гадагшаа гарлаа. Саша нөгөө тийшээ эргээд унтаад өгөв. Дахиад Василий багшийн чимээнээр сэржээ. Тэрээр эргэж ирээд бохир гутлаа тайлж, гэрийнхээ жанчийг өмсөж байв.

–За одоо бол босно шүү, босож нүүр гараа угаа, тэгээд ундаа ууцгаая.

Өглөөний хоолонд дахиад л шарсан өндөг, бас халуун бин, шахмал цай чанаж өгөв. Цөмөөрөө ажил явдалдаа явцгаачихсан, ганцхан авгай л пийшингийн хажууд юм оролдож байх ажээ.

–Та хэдтэй вэ? гэж Василий багш асуув.

–Хорин хоёртой. Та?

–Би юу? хэмээн Василий багш инээмсэглэсэнээ,

–Хорин долоотой гэв.

–Та ямар хугацаагаар заагдсан бэ? Василий багш дахиад инээмсэглэв.

–Хугацаа гайгүй ээ, гурван жил. Хоёрыг нь авчихсан, одоо ганц жил үлдээд байна. Нутаг орноо санаад, тийшээ явмаар байх юм, гэтэл эндээ дасчихаад явахад бас харамсмаар байна.

–Тэгвэл эндээ л бай л даа, гэрлэчих. Та хаашаа явах юм бэ? Орост танд бурхан мөргөл үйлдэх боломж олдохгүй шүү гэж эзэгтэй өгүүлэв.

–Бурханд хаа ч мөргөл үйлдэж болно гэж Василий багш хариулав.

Тэгээд Саша руу эргэж,

–Та эхлээд нэг хэсэгтээ уйдна, дараа нь тэгээд дасчихна аа. Сэтгэлээр унахын хэрэггүй, зүрх сэтгэлээ бүү зэврээ, юм нэгээр дуусдаггүй, муугийн дараа заавал сайн залгадаг юм. Би Александр Дюмаг уншсанаа санаж байна. Тэнд гай түүтгэр бол бидний хувь заяаны утсаар хэлхсэн эрхи, мэргэн ухаантан тэр эрхийг тайван эргүүлж байгаа юм гэж бий. Элдэв адал явдалт роман зохиож байсан зохиолч гэхэд цэцэн бөгөөд сайхан хэлсэн байгаа юм шүү гэв.

Сашаг замдаа гарахыг дуудаж хүн цонх тогшлов.

–Би танд хэдийн өглөгтэй вэ? гэж эзэгтэйгээс асуулаа.

–Хэдийн ч өглөг байхгүй хэмээн цаадах нь толгой сэгсрэв.

Василий багш тохой руу нь нударсхийж,

–Эзэгтэйн сэтгэлд бүү юм хий гэв.

Тэрээр Сашаг гаргаж өгч чемоданыг нь байрлуулахад туслав. Завьчин уяагаа задалж завиа түлхээд хошууны тэндэх сэлүүр дээр суулаа. Федя хударгаа мөрөндөө углаад урагшлах зуур завиа харж, завьчины залж байгааг ажиглан уяагаа зугуухан чангалав. Завиа зөв явж байгаад итгэмэгц,

–Арлын яг эцэст хүрэхтэйгээ зэрэг аглаг газартаа гарцгаана гэж хэлэв.

Саша Василий багшид гараа өглөө.

–Баяртай. Танд их баярлалаа.

Федя хөгжүүн дуугаар,

–Хөдөлцгөөе! гэж хашгирав.

Саша бөхийн уяагаа чивчрүүлээд урагш зүтгэлээ.

–Та нарыг бурхан өршөөх болтугай! гэж Василий багш өгүүлэв.

Гуравдугаар хэсэг

1

Ангара өгсөөд Кежмаас дээш арван хоёр километр зайтай байдаг Мозгова тосгоныг Сашад нутаг болгон зааж өгчээ.

Сайхан байр таарав. Юм юм нь хүрэлцээтэй том байшин. Гэрийн эзэгтэй бэлэвсэн авгай том болсон хоёр хүүтэй. Цэрэгт алба хааж байгаад энэ нутагт ирж суурьшсан нэгэн эр энэ авгайнд бас сууна. Тухайн үедээ хоёр хүү нь тэр хүнийг гэр бараа, мал аж ахуйд давхар эзэн гарна хэмээн эхтэйгээ гэрлүүлээгүй юмсанж. Одоо мал ахуйгаа хамтралд өгчихсөн, гэвч сайхь цэрэг ууж согтуурмагц урьдын гомдол нь сэргэж бууралтаж яваа үс нь арзайсан час улаан амьтан тосгон дундуур хэрэн гүйж, дагавар хоёр хөвгүүнээ ална хядна гэж харайлгадаг боловч цаад хоёр нь өөрийг нь барьж аваад пүнзэнд хийж нойроо авч согтуу нь гартал түгжээд орхичихдог ажээ.

Бага хүү Василий гэж сийлмэл царайтай гэлтэй сайхан залуу. Энд ёс журам гэж задгай болохоор тосгоныхоо бараг бүх охидтой энгэр зөрсөн нэгэн аж. Гэртээ үүрээр орж ирэх юм уу, эсвэл бүр үзэгдэхгүй. Саша түүнийг харах нь тун ховор, хааяа тааралдвал Василий өөдөөс нь чимээгүй инээмсэглэн харна. Нэг их юм ярихгүй ч гэсэн нөхөрсөг хандаж байгаа нь мэдэгдэнэ.

Том хүү Тимофей нь охид бүсгүйчүүлийн явдлыг огтхон ч сонирхохгүй, үдэш орой гудамжаар сэлгүүцэхгүй, гагцхүү гэртээ хононо. Сашагийн өрөө рүү дур мэдэн орж ирж, энэ юу юм бэ, түүгээр яадаг юм бэ?.. гэсэн маягтай юм хумыг нь сонжино. Гэхдээ дуугарахгүй, сэжиглэж үл итгэсэн янзтай харна. Ийнхүү эрээ цээргүй байгаад Саша дургүй нь хүрдэг боловч Тимофейг тэвчиж, асуусан болгонд нь ёсчлон хариулна. Яая гэхсэн билээ, ийм л ардууд юм чинь! Хүчирхэг аугаа их ард түмэн боловч одоо хэр харанхуй бүдүүлэг чигээрээ байгаа болохоор Саша оросын аливаа сэхээтний адил энэ байдлын бурууг өөртөө тохдог билээ.

Саша нэг удаа Тимофейтэй өвс хадахаар арал руу явжээ. Мань хүн хэдийгээр өвс хадаж чаддаггүй ч гэсэн туршихаар шийдсэн юм байж. Саша завиа сэлүүрдэж Тимофей хошуун дээр нь суугаад залуурдаж явав. Завины ёроолд хоёр хадуур, нэг гуранз, ялааны хоёр баг хэвтэнэ. Морины сүүлээр хийсэн болхи баг нь Тимофейнх, нөгөө торгомсог нь Соловейчикийн зөвлөсний дагуу Канскаас худалдаж авсан Сашагийн баг аж. Тимофей Сашагийн багийг ажиглаж хараад,

—Хотын та нарт ч байхгүй юм гэж даанч алга аа, гэтэл хөдөөгийн бид нарт чинь юу ч байхгүй, үзсэн харсан юм ч гэж ер алга, тэгсэн мөртлөө та нар л бидний хүзүүн дээр сууж байх юм гэв.

Тимофей нэмүү өртөгний онолыг хээгүй байдлаар тайлбарлах мэт материаллаг үнэт зүйлийг Тимофей бүтээж байна, тариачид бүтээж байна, харин Саша болон тэр мэтийн хүмүүс бол юу ч бүтээдэггүй гэж байх шиг Сашад санагдав. Тэрээр голын салааны урсгал ширүүн байсан тул завиа арлаас доогуур алдчихгүйн тулд хамаг тэнхээгээрээ хүчлэн сэлүүрдэх зуур тэгж

боджээ.

Гэтэл Тимофей,

–Та нарыг бидэнд лай хурааж нааш нь цөлж байна, та нар бол бидний хөлс, цусаар амьдарч байгаа улс гэж нэмж өгүүлэв.

Саша хариу хэлсэнгүй. Юу хариулж чадахсан билээ? Тимофей юмны учрыг олохсон гэж байгаа бол өөр хэрэг... Гэтэл тийм бодол даанч алга. Түүний хувьд бол Саша зүгээр л эрх мэдэлгүй цөлөгдмөл хүн, тэгэхлээр дооглож зугаагаа гаргаж бололгүй яахав.

–Айчихав уу? Хулчийчихав уу? Хадуураар ганцхан татчихаад ус руу хаячих минь, чи муу тэгээд л бараа сураггүй алга болно шүү дээ! хэмээн Тимофей хямсайн тамшаалж, –Тэглээ гэхэд надад юу ч наалдахгүй, аглаг ой руу зугтчихсан гээд л хэлчихнэ. Та нар бол муусайн эсэргүүчүүд, троцкистууд, хэн та нарыг нэхэх юм бэ? Шаар минь! гэв.

Саша сэлүүрдэн эрэг рүү дөхөж ирээд ус руу бууж завиа татахад Тимофей бууж туслахын оронд хошуун дээр суусан чигээрээ хямсайж жуумалзан байснаа Сашаг завиа бүр эрэг дээр татан гаргаад гинжээ хаямагц сая газар луу бууж ирэв.

–Чи намайг тэгээд живүүлчихгүй яагаа вэ? гэж Саша асуув.

–Донгосоод байвал дуртайяа живүүлчихнэ шүү гэж Тимофей занав.

–Живүүлээгүй чинь тоогүй юм болж дээ.

–Яагаад тэр билээ?

–Яагаад гэвэл би одоо чамайг ална гэж Саша өгүүлэв.

Тимофей нэг алхам ухартусаж,

–За за, битгий дэмий ярь! гэв.

Газрын мухарт байгаа эл хуль арал. Энэ арлын гүн рүү хэдэн хүн өвс хадаж байгаа. Ялаа шумуул бужигнан шунгинахаас өөр ямар ч анир чимээ энэ гол дээр алга. Орчлон ч алга, хүн төрөлхтөн ч алга, гагцхүү мань хоёр л байна, гэм нүгэл хийсэн хүнд шанг нь хүртээх цаг яг мөн.

Тимофей Сашагаас хараа салгахгүй зугуухан ухарч байснаа ганцхан эргээд завь руу, хадуур луугаа харайлгачихав. Саша хөөж очоод нуруу нь цохиход цаадах нь ус руу ойчлоо. Тэгээд өндийж ирээд эргэж харахад нь Саша нүүр лүү нь хүчтэй дэлсэж Тимофей дахин ус руу ойчсоноо ус үсчүүлэн эрэг рүү зүтгэлэв.

Үгүй ээ, мань хүн Тимофейг алахгүй, энэ муу хүний адгаас болж өөрийгөө баллахгүй. Тимофей босож зүрхлэхгүй Саша руу хулчийн хараад эрэг дээр хэвтэж байна. Өөдгүй новш!

Ай яасан ч гунигтай орчлон бэ...

Саша завь руу очиж хадуур, гуранз, Тимофейн багийг авч хаяад тосгоны зүг сэлүүрдэж гарав.

Саша өөр айлд суухаар шийдсэнээ оройн хоолны үеэр хэлэв.

–Манайд байхад тусгүй байна уу? хэмээн нөгөө хөгшин цэрэг асууснаа, –Тимошкаг сургаж өгсөн чинь тун сайн байна. Ямар ч хүнээс айж ичихээ мэдэхгүй, хэнийг ч бай айлгаж сүрдүүлэхийн өмнөөс төрсөн мэт мангар амьтан байгаа юм. Харин чи ч сайхан чийтэй, тэнхээтэй эр байна. Васькатай яв, эндхийн хамаг охид энүүнийх юм чинь ганц нэгийг чамд өгч магад гэв.

–Нөгөө багш хүүхэн наадах руу чинь нүд хаяад байгаа шүү хэмээн Василий инээд алдав.

Тимофей хэн рүү ч харахгүй чимээгүй сууна.

Уул нь сайхан байшин. Гэвч хэн нэгэн өстөнтэй цуг байна гэхэд ая тавгүйн гадна мань эр шиг хүний хувьд бол эгзэгтэй хэрэг. Саша маргааш өглөө нь юм хумаа шинэ байранд авчрав.

Тэр модон байшин гал тогооноос гадна зочны багавтар өрөөтэй байсныг хөлслөхөөр болжээ. Энэ айлын эзэн өвгөн эмгэн хоёр түрүүчийн айлынхнаас ядмагдуу боловч боломжийн хоол унд залгуулж байв. Хамтралынхан ажиллах нь бага, хоёр хөгшин өдөржин гэртээ байвч ам муруйх нь үгүй, өвгөн нуруу атигар, яльгүй суунги учир эмгэн нь түүнийг “миний хазгар” гэнэ. Эмгэн пийшингийнхээ дэргэд тогоо шанагатай ноцолдож, өвгөн хашаан дотор ямар нэг юм засаж сүхний дуу хааяа гаргахаар өөр чимээ анир энэ гэрт байхгүй. Зочны өрөөнд саяхан мулз угаасан шалны үнэр хамар цоргиж цагийн эрхшээлээр харласан дунзэн ханан дээр Ленин, Калинин хоёрын хөрөгний хажууд “Нива” сэтгүүлээс хяргаж авсан задгай сүйх тэрэгтэй хааны халуун ам бүлийн зураг өлгөөстэй байна.

Өвгөн заримдаа өдөржин эзгүй яваад орой эргэж ирнэ. Хамтралдаа юу хийв? гэж асуухад,

– Хий гэснийг нь л хийлээ гэж хариулна. Хамтрал гэдэг бол эндхийн хувьд харьцангуй ухагдахуун. Хамтралжуулалт энд бусад мужаас хожуу эхэлсэн, гэтэл Сталины “Амжилтаас толгой эргэх” гэдэг өгүүллийн дараагаар хамтралууд бүрмөсөн задран унаж дахин эмхлэн байгуулах ажил мөн л жил хагас, хоёр жилээр хоцорсон ажээ. Ер нь эндхийн юуг нь хамтралжуулах юм билээ дээ? Тариа боловсорч гүйцэх хугацаа бараг байхгүй учраас дөнгөж ам бүлээ тэжээх төдий ургац авна. Гэтэл энэ тариаг нь эздээс нь хураагаад авчихлаа гэхэд түүнийгээ зургаан зуун километр газар чаргаар зөөх буюу Ангарын харгиа боргиогоор салаар авч явах арга даанч байхгүй. Мал юусан билээ? Айл болгон арваад үнээтэй гэвэл тосгоны хэмжээгээр хоёр мянган толгой үхэр, түүнээс гадна мянгаад адуутай байсан. Түүнийгээ нийгэмчилж хөөгдсөн нударганчуудын хашаа хороонд тууж аваачсан, гэтэл эндхийн өвөл хахир хатууг ч хэлэх уу, хамаг малынхаа тэн хагасыг үхүүлчихсэн ажээ. Үлдсэнийг нь айл айлд тарааж өгсөн, гэхдээ аминд нь буцааж өгсөн биш хамтралын мал чигээр нь тараажээ. Гэтэл суугээ хааш нь хэнд тушаах вэ? гэдэг асуулт гарч. Сүүний үйлдвэр ч байхгүй, цөцгий цохих газар ч байхгүй. Кежма руу дарга нарт зориулж зөөх хэрэг үү? Харин дарга нарын тооны хувьд гэвэл харсаар байтал шингэрч байгаа малый тоотой жишихийн аргагүй түргэн

өсөж байгаа билээ. Ингээд үлдэж байгаа гол юм ан гөрөө. Хамниганууд руу очих, Ванарава явах гол зам чухам энэ Мозговаас эхэлдэг юмсанж. Хамтралжуулахаас өмнө хэрэмний арьсыг “Ангийн үс бэлтгэх газарт”, хоршоонд тушаадаг байсан юм. Гэтэл одоо хамтралд тушаах юм гэнэ, тэгвээс хамтрал өртөгнийх нь хагас хувийг өөртөө суутгаж авна. Ингэхлээр яах вэ? Анчид ангийнхаа үсийг нуун дарагдуулж байгаад хамнигануудад зардаг болжээ. Тэндхийн бэлтгэлийн газар бүтэн үнээр нь авдаг учраас тэр.

Ангийн үсний тоо хэмжээ буурчихсаныг төвийнхөн хоёр жил орчмын дараа сая ухаарчээ. Уул нь валютын түүхий эд шүү дээ! Тэгээд комисс явуулж баахан яриа хөөрөө болсны эцэст хамаг хэрэг газар тариалангаас болж байна, газар тариалан таваарын бүтээгдэхүүн өгөхгүй, улсад ямар ч ашиггүй мөртлөө анчдыг тэр ажлаас нь хөндийрүүлж, гагцхүү хор хүргэж алдагдал учруулахаас өөр юм алга, тийм учраас энэ нутгийг газар тариаланд таарахгүй, зөвхөн ангийн үс олборлохоор төрөлжүүлнэ хэмээн тунхаглаж тариа будааг хамниганчуудад зөөдгийн нэгэн адил газар тариалангийн өөр районуудаас зөөж байхаар шийджээ.

Гэтэл өөрснийг нь тариа тарихыг хориглосон хэрнээ зөөж авчирч өгөхөө мөнөөхөн мартчихсан тул нөгөө анчид маань одоо болохлоор ангийнхаа үсийг хамнигануудад гурил, будаанаас гүйлгэх болжээ. Тэгээд дарга нартаа хэрэм хойшоо дүрвэж нүүчихээд байна, тийшээ хүрч очих гэсээр байтал гурван долоо хоног өнгөрөх юм, очсон хойноо шинэ нутагт өвөлжөөний байр барих хэрэгтэй, гэтэл тэр байрыг нь нөгөө хамниганууд эвдэлж нураагаад бараг л буудалцахдаа хүрэх нь халаг юм болж байна хэмээн өөрснийгөө зөвтгөнө. Үнэн хэрэг дээрээ бол хамнигануудтай урьд хожид үзэгдээгүй ойртон нөхөрлөцгөөж ангийнхаа үсийг талх тарианаас төдийгүй ихэнхдээ спиртнээс өгдөг болсон ажээ. Бэлтгэлийн газарт хамнигануудад байхгүй юм гэж байх биш. Тэгээд л нийлээд архидаж гарцгаана.

Улсад жилдээ зуун мянга хүртэл хэрэмний арьс тушаадаг, малаа бэлтгэж Эрхүү рүү туудаг, талх тариа, сүү сааль, загасны махаар өөрийгөө хангадаг байсан сибирийн бөглүү тосгон ан гөрөөгөө орхиж тариа тарихаа больж, малынхаа тоо толгой арав дахин бууруулчихаад Ангара орчмын бусад тосгон суурины хамт Алтай нутгийн тэртэй тэргүй өөрснөө ам хөдөлгөх юмгүй болсон тариачдын нуруун дээр мордчих нь тэр.

Тэглээ ч гэсэн Ангарынхан гучаад оны эхний өлсгөлөнд хараахан өртөөгүй болой. Алс холын хаягдмал байдал бас үе уламжилсан чухамдаа бодит аж ахуй нь л аварсан хэрэг. Нэг талаас гол мөрөн нь тэжээсэн. Хадар, тул түрсээ шахахаар энэ нутаг руу дээшилж ирдэг улаан загас энэ тэр загасыг малгайгаараа хутгаад авсан ч болно, нөгөө талаас ой хөвч нь жимс мөөгөөрөө тэжээсэн. Бас хамтралын фермийг даруй гурав дахь жилдээ барьсаар байсан тул үлдсэн хэдэн үхэр нь хэдийн хамтралынх нь ч гэсэн айл айл дээрээ байсан болохоор мөн л амь зуулга залгуулсан. Тэжээвэр шувуу, ганц торойтой мэгж, мөн ноосны хэдэн хонь энэ тэр гээд хараахан нийгэмчлээгүй гэрийн амьтад нь муу юм үзүүлээгүй. Гол юм юу вэ гэхлээр, улсад тушаах юмны төлөвлөгөө байхгүй, ангийн үснээс өөр бэлтгэлийн төлөвлөгөө байхгүй билээ. Ангийн үснийх нь төлөвлөгөөг ч гэсэн жилээс жилд бууруулсаар бүр сүүлдээ энэ районыг газар тариалангүй төдийгүй ан агнуургүй бүс болгож санаа амарчээ. Тэгээд сүүний аж ахуйн район болгон тогтоож, Кежмагийн хамтрал хооллож ундалж гүйцэхээ болиод байгаа районы дарга нарыг өдөр бүр шинэ сүүгээр хангаж байх үүрэг оноожээ. Мозгова сүү нийлүүлэх үүргийг ёсчлон биелүүлж байв. Хоёр мянган үнээнээс нь хоёр зуу үлдсэн болохоор үүнд нэг

их төвөг байсангүй, тэргэн дээр арван бидон сүү тавиад явуулчихна. Тэгээд л болох нь тэр.

Сашаг ирэхэд тэр тосгон хараахан тартагтаа тулаагүй байжээ. Мөнгийг юм гэж тоодог байсан учир тэрээр байр, хоолны өртгөнд гэрийн эзэнд хорин рубль төлнө. Заримдаа нийгмийн сүүний машин засахдаа бүтэн хувин цөцгийтэй ирнэ.

Тэр сүүний машин нь задалж цэвэрлэхэд тун ярвигтай, өнгөрсөн зууны сүүлчээр үйлдвэрлэсэн шведийн “альфа-С” хэмээх олон давхар дийзтэй машин. Саша гурван жилийн өмнө үйлдвэрлэлийн дадлага хийж байхдаа сүүний машиныг мэддэг болсон ажээ. Тариа хураах ажлаар автомашины цуваа хөдөө явуулсан юмсанж. Хөрөнгөө хураалгасан нэг нударганаас сүүний машин үлдсэнийг ажиллуулж мэдэх хүн огт байсангүй. Авто цувааны механикч эр машиныг задалж цэвэрлээд буцааж угсарчээ. Саша тэгэхэд сониуч зан гарган бас задалж угсарч үзсэн нь одоо ийнхүү хэрэг болжээ. Энэ машин хуучирсан гэдэг учиргүй, гол тэнхлэгийнх нь эрчлээс бүр элэгдчихсэн, эм эрэг нь дөнгөж тогтох төдий байжээ. Эрчлээсийг нь шинээр зорьё гэхэд даанч багаж байхгүй.

–Сүүнийхээ машиныг Кежмад аваачиж шинэ эрчлээс гаргуулбал таарна гэж даргадаа хэлээрэй, эс тэгвэл энэ чинь нураад ойчно шүү гэж Саша сануулдаг байжээ.

Гэвч даргад нь энэ сүүний машинтай ноцолдож байх зав байхгүй байсан юм уу, эсвэл хамтралын авгай нар Сашагийн хэлснийг түүнд дамжуулдаггүй байв уу!

Сүүний машин бол нөхөртэй авгай нарын зугаагаа гаргадаг ганц газар. Сүүний машин дээр очоод ирье гэдэг бол гэрээсээ ганц цаг ч болохноо хөндийрч, сүүгээ машиндах ээлж болтол амны зугаа гаргана гэсэн үг бөгөөд арга барагдам хувь тавилантай хүнд амсхийх гэгээ болдог буй заа. Энэ нутгийн хүүхнүүд тарианы талбай, ногооны хашаа, мал ахуй, гэр орон, ус унд гээд хамаг ажлыг үүрдэг улс. Жинхэнэ ангарын харчуул бол аливаа ажил, ялангуяа гэр орны ажлыг ад үздэг анчид, тэнүүлчид билээ. Эндхийн бүсгүй хүн хорин насандаа чөдрийн адуу, гучин насандаа адсага болдог гэж Соловейчикийн хэлсэн үнэн байна. Бүсгүйчүүдийн нар гардаг үе бол хүнтэй суухын өмнөх арван гурваас арван зургаан насны үе. Хэдийгээр охидууд гэр орны болон хамтралын ажлыг яг томчуултай адилхан нугалдаг ч гэсэн орой нь гудамжнаа гадаалах гэж нэг сайхан юм тэдэнд бий. Охидууд хоёр хоёроороо эгнэн дуулан алхацгаахад араас нь хөвгүүд мөн хоёр эгнээ болоод гармонь хуурчийн хамт дагацгаана. Тосгоны зах хүртэл яваад буцаж ирцгээнэ, тэгээд дахиад явна, тийнхүү бүрий буутал явцгаах бөгөөд эцэст нь хос хосоор өвсний хороо, үтрэмээр сарнин тархацгаана. Хожим эр нөхөр нь авгайгаа муучлахдаа хүрвэл чухамхүү онгон бүтэн байснаар нь мууг нь дуудна. Хүнтэй суухдаа тийм байна гэдэг бол охинцор байхдаа хүртэл хэнд ч хэрэгцээгүй байсан гэсэн үг.

Тимофейг зодсон явдал санаснаас өөрөөр эргэж, цөлөгдмөл хүн нутгийн эрийг дэлсэхээс айсангүй хэмээн харин ч Сашагийн нэр хүнд дээшилжээ. Цөллөгийнхнийг аль эзэн хааны үеэс нааш өөгшүүлж муу зан сургадаггүй, хулгай хийх, ууж согтуурах, зодоон хийх энэ тэрд тосгоноороо нэгсэж байгаад шийтгэчихдэг байжээ. Дараа нь буруутай эзэн нь олдоно гэж байх биш. Гэхдээ тэд нар бол дандаа эрүүгийн ялтнууд байдаг байсан, улс төрийнхөн бол нударга зөрөлцөх нь үгүй билээ. Гэтэл энэ цөлөгдмөл бол нөгөө жинхэнэ Москвагийн хүн, элдэв мэх мэддэг учраас хэнээс ч айхгүй хэмээн хоршоочин Федя Сашагийн тухай яриа дэлгэж, аян хамтад өөрийнхөө боловсролтойг харуулахын тулд мэх гэхчлэнгийн хүн мэдэхгүй

үг ярих ажээ.

Чухам Федягийн ачаар л Саша Мозговад таарчээ.

Богучанын Дотоод явдлын ардын комиссарын газрын бүрэн эрхт төлөөлөгч нөгөө нойрмог лазан нөхрийг бодвол Кежмагийн бүрэн эрхт төлөөлөгч Алфёров гэдэг санаа зовмоор туранхай ч гэсэн галав шалавхийсэн хүн агаад тэрээр Сашаг сонжин хараад,

–Юугаар ирэв? гэж огцомхон асуужээ.

–Мозговын нэг хоршоочинтой ирлээ.

–Тэр чинь яваад өгсөн үү?

–Үгүй.

–Тэгвэл түүнтэйгээ хамт Мозгова руу явчих гэж Алфёров шийдвэр өгчээ. Нэгэнт хүн унаа олчихсон яваа юм чинь тэр чигээр нь явуулчихвал амар гэж бодсон бололтой.

Кежмаас арван хоёрхон километр зайтай газар аж төрөх нь, түүнээс гадна сайн ч бай, муу ч бай эрхиш танилтай боллоо гэж Саша ч бас сэтгэл ханажээ.

Федя нэг орой Саша дээр ирж гадагш нь дууджээ. Нарийхан хөндлөн гудамд хураалттай гуалин дээр Лариска гэдэг батган нүүртэй, царай дортой салмал хүүхэн, Федягийн дүү Маруся гэдэг өргөн хавтгай царайтай, дөрвөлжин биетэй гэнэхэн бүсгүй хоёр сууж байв. Лариска онигор нудээрээ хялалзан байх ажээ.

Федя Ларискагийн хажууд гуалин дээр суух зуур,

–Манай дүүгийн тэнд суу гэж Сашад өгүүлэв.

Маруся Сашаг харж зэрэгцэж суугаад миний мөрөөр тэвэр л дээ, зөөлхөн мөр байгаа биз дээ, бас сайхан зузаан цээж байна, дулаацаж болно шүү гэсэн маягтай найр тавин инээмсэглэв.

Гэвч мань эр ямар ч атугай зайдуухан суув. Жаахан биеэ бариад байлаа. Богучанын Лукешка бол цаанаа л нэг өсөж яваа насны сэргэлэн зантай, аль нэг байдлаараа Катяг санагдуулам, ичих зовох юмгүй гэнэхэн янзаар тоглож байсан билээ. Тэрээр энэ бүдүүн дөрвөлжин хүүхэнтэй юу ярихаа мэдэхгүй байв. Ер нь ч энүүнд юм ярихын хэрэггүй, үг дуугүй өвсний хороон дотор ойчоод өгөх амьтан байх...

Гудамжнаас дуу дуулах, гармонь хөгжим эгшиглэх сонсогдоно. Зида буюу Нурзида Газизовна гэдэг хорин тав, зургаан насны татар багш эмэгтэй явж өнгөрөв. Эндхийнхэн түүнийг Зина, Зинка гэх агаад сурагчид нь Зинаида Егоровна гэнэ. Саша болон түүний шинэхэн танилуудын сууж байгаа гудамжны түүгээр тэдэн рүү хараад зугуухан явж өнгөрчээ.

Маруся цайлган сэтгэлээр инээмсэглэн,

–Чамайг хайж явна гэж Сашад хэлэв.

–Намайг байдаг нь юу билээ?

–Нүдэнд нь тусаж л дээ. Би чамайг уулзуулаад өгөх үү?

Надад дургүй байгаа бол өөр хүүхэн ав, би өөрөө хүргээд өгье гэж байгаа мэт Марусягийн энэ хар муу санаагүй илэн далангүй зан Сашад аятайхан санагджээ. Гомдох санах юмгүй санаа амар юм даа.

–Хэрэггүй ээ гэж мань эр хариулав.

–Юу нь дэмий байна?

–Дэндүү туранхай байна гэж Сашагийн өмнөөс Федя хариулав.

–Тэгсэн ч гэсэн хотын даашинзтай, торгон өмдтэй байна шүү дээ гэж Лариска ярианд оров.

–Гэтэл тэр өмдний цаана дан яс бий гэж Федя зөрөв.

Тэгээд босож суниав.

–Лариска, явья, бин маань хөрчихнө.

–Би хүрмэндээ боочихсон, халуунаараа байгаа. Лариска хашаан дотор явж байхдаа,

–Та нар саравч руу гарч бай, би бингээ аваад ирье гэв.

Тэд нар модон шатаар авирч өвсний саравчин дээр гарцгаалаа. Нэг жил өнжсөн өвсний үнэр ханхална. Сартай тунгалаг шөнө Марусягийн дугариг царай гэрэлтэн Сашад амьсгаа нь хүртэл сонсдон, хүлээсэн харц нь мэдэгдэх шиг болов. Федя саравчны нуруун доогуур тэмтрэхүйд гарт нь лонх гялсхийж, тэр даруй шилэн аяганууд харшилдлаа.

Саша энэ шөнийн явдлыг бүдэг бадагхан санаж байв. Лариска, Маруся хоёр жаахан уусан, харин мань эр Федягаас дутахгүйн тулд аяганы тэг дундуур цэвэр спирт уучихжээ. Тэгтэл хоолой түлчих шиг болж бушуухан усаар даруулж, борцолсон загас зажилж байсан, тэгээд цаашаа ааг орж, Москвагийнхан яаж ууж чаддаг тухай сайрхаж байсан нь санагдана. Тэгсэн чинь юу юугүй дэврэн хөөрч, тэнгэрт нисэхээс буцахгүйдээ хүрч гайтай хувь тавилангаасаа зугтан өөрөө өөрөөсөө зайлахын түүс болж, нэмж уух гэж спирт нэхэж байжээ.

Федя шилээ өргөн дахиад спирт байхгүй гэдгийг харуулна.

Дараа нь нэг мэдэхэд бөөлжиж байсан, гэхдээ өвсний саравчин дээр биш өтөг бууц ханхалсан газар дээр. Федя, Маруся хоёр өөр лүү нь тонгойн царай нь цайвартан харагдаж, шанагатай ус шүд рүү нь мөргүүлж, бас хүзүү рүү нь ус хийж байсан. Мань хүн өндийгөөд нэг тийшээ явах гэж оролдсон, гэтэл дахиад л дотор муухайрч, тавьж түйхгүй огиулж гарсан. Алсын тэнгэрт одод гялалзан, энд тэнд ноход хуцалдаж, цаадуул нь мань хүнийг нэг тийш нь чангаацгаан

өөрөө үлдэж цааргалан байсан, гэхдээ гэрийн эздийг сэрээхгүй, шившгээ тарихгүй хэмээн өрөөндөө цонхоороо мөлхөж орсон.

Өглөө гэрийн эзэд ажилдаа явцгаах гэж байгааг сонссон боловч унтаж байгаа дүр үзүүлж байснаа тэр чигээрээ нойрсчихоод нэг сэрэхэд нь байшинд нэг ч хүнгүй байв. Босоод зоорь луу ороход газар доорх чийглэг сэрүүн агаар аятайхан жиндүүлэв. Тавиур дээрээс модон тагтай вааран аягатай цөцгийг авч дээшээ гал тогоонд орж ирээд алчуур дороос одоо хэр бүлээнээрээ байгаа зөөлхөн талхыг авч цөцгийндээ дүрж байгаад идэв. Тэгвээс бие жаахан тавирч тэгээд орой болтол нам унтаад үдшийн хоолон дээр босож ирэв. Гэрийн эзэд юу ч асуугаагүй гэсэн юу болсныг мэдэж байгаа гэдэгт Саша эргэлзэхгүй байв.

Маргааш өглөө нь бие бүр хөнгөрөөд сайхан болчихсон хэрнээ ямар ч урам байдаггүй. Федя, Маруся, Лариска энэ тэртэй тааралдахаас айж, тэдний доогтой харцтай учирна гэхээс ичингүйрч гэрээс гармааргүй санагдан, яаж байгаад тэгж гахай шиг болсноо ойлгож ядав. Хэтрүүлж уусны тухайд бол тиймэрхүү явдал байхыг алийг тэр гэх вэ, харин онгирч дэмий донгосохын тухайд бол хэзээ ч тэгж байгаагүй билээ. Гэвч тамхи нь дуусчихсан учраас хоршоонд очихоос өөр аргагүй болов. Федя түүнийг найрсаг инээмсэглэн угтлаа. За сайн уу? Толгой яаж байна? Дажгүй биз? Тэгвэл болоод явчих нь тэр! Тэгээд тамхи, шүдэнз өглөө. Бас өөрөө сурах заавартай гитар худалдаж авахыг санал болгов. Гурван ширхгийг ирүүлсэн чинь хамниган, сибирийн орос хоёроос гитар тоглодог хүн даанч алга. Саша гитар авсангүй, гэхдээ хожим тэр тухайгаа харамссан билээ. Тоглоод сурчихсан ч байх юм билүү?

Гудамжинд голоос ус аваад тэгнүүрдэн явж байгаа Марусятай тааралдахад цаадах нь юу ч болоогүй мэт ердийн байдлаараа инээмсэглэн уулзжээ.

Тосгоныхон энэ явдлыг даанч тоосонгүй, мань хүн дэмий санаа зовсон хэрэг байжээ. Архи уусан хүн яадгийг мэдэхгүй хэн байх билээ. Түүнээс гадна нөгөө спирт нь хоршооных байсан, тэд үнэгүй юм гударсан учраас Федя хоёр хүүхэнд амаа хамхиж явахыг тушаасан юмсанж.

Сашатай энэ тухай ярьсан ганц хүн бол Москвагаас цөлөгдөж ирсэн гучин тав эргэм насны Всеволод Сергеевич гэдэг халзан толгойтой, төмсөн хамартай, нимгэн зэрмэгэр уруултай болохоор наснаасаа ахимаг харагддаг шөрмөслөг шуугдмал эр юм. Тэрээр үнэн цагаан сэтгэлээсээ инээмсэглээд юу эс тохиолдох вэ дээ... хэмээжээ.

Тэр хүн юуны учир цөлөгдсөнөө эс ярина, ер нь энд тийм заншилтай. Цөллөгийнхөн замд явж байхдаа юмаа илэн далангүй ярьдаг боловч энд ирсэн хойноо бол гагцхүү зүйл ангиа л хэлнэ. Бараг бүх хүний зүйл анги тавин наймын арав.

Всеволод Сергеевич цөллөгийнхөө хугацааг эхлээд Кежмад өнгөрөөж байсан боловч районы санхүүгийн хэлтсийн нэг албан хаагч хүүхэнтэй сэмбэгнэсний учир Мозгова руу хөөгдсөн ажээ. Цөллөгийнхөнд энэ явдал хориотой байдаг учраас тэр. Энд ямар газар мундах биш дээ, Мозговаас бүр хол зуун километрийн цаана ч хөөчихсөн чадах байсан боловч Кежмад алба хаалгахаар үлдээжээ. Гэхдээ өдөр болгон хорин дөрвөн километр явган явах ёстой болжээ. Гэтэл тойргоос нягтлан бодогч ирүүлсэн учир Всеволод Сергеевичийг хавар албанаас нь халж одоо Мозгонад мужаан хийх, өвс хадаж хураах, ногооны талбайн газар хагалах, хамтралын тоо бүртгэгч гэж Канскт курс төгссөн бандид туслах зэргээр хэдэн мөнгө олох

болсны гадна загасны жижиг задгай тор барин шуудагтай гадуур явж тосгоныхны нүдийг орой дээр нь гаргана. Цаадуул нь дотуур өмд өмсөхөөс биш шуудаг гэж ерөөсөө үзээгүй болоод тийн гайхацгаадаг ажээ.

Гэвч энэ хүн гагцхүү авгай хүүхнийг амьдрал хэмээн үзэж бүсгүйчүүлийн тухай илэн далангүй, ичиж улаймаар юм ярина. Нэг удаа Саша нүүрээ үрчийлгэн ярвайсхийхийг хараад,

—Чи бидний энэ насанд одоо юу үлдсэн бэ? Та энд юу хийе гэж бодож байна? Сэтгэлээ баярлуулах ганц юм бол хүүхэн, өөр юу ч олодохгүй. Комендантын газраас өгч байгаа юухан хээхнийг их юм гэж бодох хэрэгтэй. Эр хүн гэдгээрээ байсан цагт та хүн хэвээрээ байна гэсэн үг хэмээн элдэв гомдол саналгүй өгүүлжээ.

Саша Всеволод Сергеевичийн ийм ярианд дургүй нь хүрдэг боловч түүнтэй нөхөрлөсөөр байв. Тэрээр хориод оны Москва, Сашагийн бага насны Москвагийн үг яриа, явган шог, цыганы уянгын дуу энэ тэрийг аль нэг байдлаар санагдуулдаг аж. Аятайхан баргил хоолойгоор “Аз жаргал минь өндөр өргөөнд байвч аливаа хүүгийн хөл хориотой өргөө юм...” хэмээн дуулна. Цаанаа л нэг эрх дураараа янзтай байх шиг санагддаг нь тэр үеийн хүнлэг чанарын илрэл байсныг Саша хожим ойлгожээ. Харин гучаад оны Москвагийн хүний янз ер эс мэдэгдэнэ. Үзвэл Москвагаас аль эрт гарсан бололтой. Тэрээр Сашагийн навс согтсоныг яаж мэдсэнээ хэлэлгүй духаа үрчийлгэн,

—Цаадуул чинь таны үерхэх хүмүүс биш. Багш хүүхнийг тогтож хараарай. Сайхан байж байгаа, боловсон байж байгаа хоёрыг нь! Тийм сайхан амьтан Ангарад хийсээд ирсэн байгаа юм даа гэжээ.

—Ийм бөглүү зэлүүд нутагт ирснийг нь би ч бас гайхсан шүү гэж Саша үнэнээ хэлэв.

—Хайр сэтгэлийн шуурганаас болоо биз дээ хэмээн Всеволод Сергеевич тосгуулан авч, —Гуч дөхөж яваа ганц бие хүүхэн, зүгээр ч үгүй дорно дахины хүүхэн ч ёстой бал бурам, ёстой тансаг цэцэг дээ... гэв.

—Тэр чинь татар хүүхэнтэй адилгүй юм байна билээ гэж Саша өгүүлэв.

—Сибирийн татарууд чинь бүр оросжиж орхисон улс, Тобольск, Томск, Кузнецкийн татарууд яг л оросууд, яг л сибирийнхэн гэсэн үг. Лалын сүсэг үү? Одоо ямар юмных нь лалын сүсэгтнүүд байх вэ дээ? Үнэн алдарт сүсэгтнийг хүртэл олоход бэрх болсон цаг!.. Гэхдээ үндэсний зан чанар, хэв маяг мэдээж хэвээр үлдсэн, ялангуяа хүүхнүүд нь эрийн боол, шударга үнэнч хэрнээ омог бардам хань хэвээрээ байгаа. Цаадхын чинь харцанд хаан хүний янзнаас юм бий шүү... Танд үнэнийг хэлэхэд намайг тоогоогүй. Яагаад ий? Хэн мэдэх вэ дээ? Харин та бол өөр шүү... Саша, үйлс чинь бүтэх болтугай! Аливаа юм улирч өнгөрдөг, харин хувь заяагаар амьдралд учирч явсан хүүхнүүд л сэтгэлд үлдэнэ. Түүнийг хөөцөлдөж зугаагаа гарга. Одоо цагт чинь ийм хүүхэн ховор шүү, та надад итгэж болно. Ийм хонгор Москвад ч гэсэн нэр төртэй шан болно гэж мэд хэмээн Всеволод Сергеевич хэлэв.

—Тэр хүүхэнд муу болж мэднэ шүү дээ гэж Саша өчив.

–Өөр багш олдохгүй юм чинь гайгүй гэж бодож байна. Бас түүнийг яг эргүүлж байгаа хүн байхгүй болохоор хов хүргэх тодорхой эзэн гарахгүй. Мэдээж олны өмнө сайрхаад байх албагүй л дээ. Их л сайндаа Савино юм уу Фролово руу нутаг заагдана биз, тэр дайны үнэ өгөхөд ам баримгүй бүсгүй.

Тосгоны салбалзсан урт хормойтой банзалтай, өргөн шанаатай, хөл нүцгэн, бахимхан бүсгүйчүүлийн дэргэд хот газрын бариу оготор даашинзтайдаа болоод жижигхэн охин шиг харагдах намхан туранхай Зида харь нутгийн өмгөөлөл ивээлгүй амьтан шиг санагдана. Хичээл номыг цаг дэмий нөхцөөсөн хэрэг, сургуулийг бөөн хар дараа гэж үздэг хөвчин тайгын бөглүү тосгонд явуулаар ирсэн, ганц бие хөөрхий багш эмэгтэй.

Тэрээр Сашаг мухлагт байхад тийшээ орж иржээ. Санаандгүй орсон хэрэг бус байж. Борхон нүдээрээ эгцлэн харахуйд харц нь сэжиг ажиггүй даруухан хэрнээ яльгүй хайш яйш янзтай ажээ. Санаа тавьсан байртай ялдамхан инээмсэглэнэ. Тосгоныхон бүгд л хоорондоо танил байдаг болохоор Сашатай ердийн танилтайгаа ярьж байгаа мэт энгийн ярьж байв. Тэглээ ч гэсэн харцных нь угт өөр ямар нэгэн юм мэдэгдэх ажээ...

Даруй хоёр жил дараалан саван ирэхгүй байна. Бас керосин, шахмал цай авчирсангүй, эрээн даавуу ирсэн ч гэсэн энд хэрэгтэй өнгө нь алга хэмээн Федя гомдол мэдүүлж гарав. Зида түүнийг анхааралтай сонсон зовлонг нь ойлгож байвч ойлгохоос цааш яаж ч чадахгүй болохоор нэг хоёрхон үгээр хариу хэлэх төдий байв.

Саша энд борлуулахаар ирүүлсэн маалинга, хөвөнгийн тухай нэг номын хуудсыг хэд эргүүлэв. Энэ нутагт маалинга, хөвөнгийн алийг ч тариалдаггүй билээ.

–Манай сургуульд уншмаар ном бий шүү, та авмаар байна уу? гэж Зида санал тавив.

–Юун сайн юм бэ!

–Орой завинуудын тэр лүү очоорой, би аваад ирэмз.

Зида ердийн байдлаар үнэн санаанаасаа ийн өгүүлэв. Гэхдээ Федяг арынхаа хаалгаар агуулах руу орох хооронд ингэж хэлсэн ажээ.

Орой тэр хоёр голын эрэг дээр нойтон мод, загас, давирхай, ханхалсан завинуудын дэргэд уулзав. Зида пальто өмсөж бүх товчоо товчилсон боловч толгой нүцгэн байв. Сарны гэрэлд түүний тод хөөрхөн царай бүр жаахан охиных шиг нялх харагдах бөгөөд гагцхүү харц нь нас бие гүйцсэн хүүхний туршлагыг илтгэнэ.

–Танд ямар ном хэрэгтэйг би мэдэхгүй байна. Манайд оръё, та өөрөө харна биз.

Саша түүнийг өөр лүүгээ наалдуулаад зөөлөн уруул дээр нь үнсэхэд бүсгүй нүдээ аньж зүрхнийх нь цохилт мэдэгдэв... Тэгснээ ухартусаж Саша руу нэгэнтээ харснаа гараас нь аятайхан сугарч,

–Байз л даа гэж шивнэв.

Хүзүүн дэх алчуураа зассанаа Сашаг сугадаж авав. Тэр хоёр эрэг даган явж дараа нь халуун усны хар хар байрнуудын дэргэдүүрх зөргөөр налуу дэнж өөд өгсөв.

–Энд байзнаж бай, намайг гэрэл асаахаар ороод ирээрэй.

Саша халуун усны байрны харласан дүнзийг налан хүлээзнэв. Цонхонд гэрэл гялсхийлээ. Саша гөрмөл хашаан дээгүүр сэвхийтэл давж байшин руу очлоо. Хаалга онгорхой байв...

Тэрээр Зидагийнхаас үүрээс өмнөхөн гарч нөгөө ирсэн замаараа халуун усны хажуугаар өнгөрч эрэг даган явсаар тосгоны нөгөө талаас өөрийнхөө байр луу ирэв.

Тэр хоёр уулзах тухай болзсонгүй, бүхэл бүтэн өдөр байгаа юм чинь тохиролцож амжилгүй яхав. Гэвч Зида Кежма явсан тул тэр хоёр уулзалдсангүй.

Саша үдэш болсон хойно гадагшаа гарав. Тосгон тэр аяараа нойрсож байвч Зидагийн цонх гэрэлтэй байх ажээ. Саша өчигдрийнх шигээ хашааг сэвхийтэл давж очоод хаалганы бариулаас татахуйд хяхтнасхийн онгойв.

–Чи яагаад хаалгаа түгжээгүй юм бэ?

–Чи хүрээд ирвэл яах вэ...

Зида оросоор хөндлөнгийн ямар ч аялгагүй цэвэрхэн ярих бөгөөд бусад талаар бол Всеволод Сергеевичийн хэлсэнчлэн аргагүй л дорно дахины хүүхэн аж. Номхон дуулгавартай хэрнээ Сашаг хүрэхтэй зэрэг тачаал нь оволзсон галзуу янаг нэгэн болой... “Чи чинь намайгаа яаж байна аа...” Тэгсэн мөртлөө дорно зүгийн даруу байдал, тэр ч байтугай бүрэг зан илт мэдэгдэнэ.

Өөрийнхөө тухай ярихдаа тун дурамжхан, бараг юм хэлэхгүй. Нэг удаа нөхрийнхөө тухай дурссанаа хуучин нөхөр гэж тэр дорхноо залруулсан. Томскт байдаг гэрт нь, аав ээж дээр нь охин нь хоцорсон, нэр Роза, нас таван ой өнгөрөөд явж байгаа. Зида мөн Томскт багшийн дээд сургууль төгсөж таван жил багшилсны дараа ийшээ яваад иржээ. “Тэндхийн бүх юмнаас залхаж гүйцсэн юм”. Гэхдээ чухам яагаад энэ бөглүү газар ирснээ эс ярина... “Ингэж л таарсан юм...” Тэр хоёрын харьцаа нууц байх ёстой, өөрийг нь элдэв муу юманд өртөхөөс болгоомжилж ингэж байна гэж Сашаг хэлэхэд тосгонд ийм нууцыг дарж байхын аргагүй гэдгийг гарцаагүй ойлгож байсан хэдий боловч түүний хэлснийг дуугүй зөвшөөрчээ. Гэхдээ уйлах дуулах, уцаарлан муудалцах, дэврэн баярлах, хайр сэтгэлээ илчлэх энэ тэрийг алийг нь ч үгүй гэхгүй, алийг нь ч заавал тэгнэ гэхгүй. Харин Саша нэг удаа шөнө сэрээд Зида сэрүүн, тохойлдсон гараа дэрлээд өөрийг нь хараад байж байхыг үзжээ.

Тэгээд хүүхний хацрыг илэв.

–Унтахгүй яагаа вэ?

–Юм бодож байна.

–Юу бодоо вэ?

Хүүхэн инээд алдаад,

–Ийм гоё хүмүүс хаа төрдөг тухай бодож байна гэжээ.

Нэг удаа Сашаг урьж дуудаж ирцгээсэн нь сүүний машин дахиад эвдэрчихсэн юм байжээ. Тэрээр саяхан бас зассан учраас эрчлээс нь идэгдчихээд эм эрэг нь барихаа больж яагаад ч нэмэргүй гэдгийг үзсэн билээ. МТС руу аваачиж янзлуул гэж хичнээн удаа хэлж байгаа билээ, гэтэл одоо хүртэл аваачдаггүй шүү.

Тэглээ ч гэсэн Саша тийшээ очжээ. Сүүний машины дэргэд авгай хүүхнүүд ам мэдэн бурцгааж байв. Хамтралын дарга Иван Парфёнович гэдэг чийрэг бадриун эр мөн тэнд зогсож харагдана. Саша түүнийг танихгүй ч гэсэн хамтралчдаа нударгаар сургадаг догшин эр гэдгийг мэдэх ажээ. Зид аяг түүнтэй ярилцаж байснаа Саша руу нүднийхээ булангаар харав.

–Сайн байцгаана уу, юу болчихоо вэ? гэж Саша хөгжилтэй өгүүлэв.

Юу болсныг өөрөө ч харлаа. Сүүний машин л задраад ойчсон байна. Яг л ингэх ёстой байсан юм.

–Энэ чиний ажил уу? гэж Иван Парфёнович асуув.

–Яагаад минийх байх билээ? Шведийнхний ажил. Энэ сүүний машиныг шведүүд хийсэн юм гэж Саша өчив.

–Швээц, Швээц гэнэ шүү. Хэмхэлчихсэн хойно одоо зас хэмээн Иван Парфёнович зэвүүн бувгнав.

–Би энийг чинь хэмхлээгүй, ер нь хэмхэлсэн хүн байхгүй. Энэ машин чинь зуун настай эд, голынх нь эрчлээс элэгдчихсэн байна билээ, МТС руу аваачиж шинэ эрчлээс татуулах хэрэгтэй гэж би хэд хэд хэлсэн шүү дээ.

–Чи хэнд хэлсэн гэж?

Саша авгай нар руу зааж,

–Бүгдээрэнд нь хэлсэн, бүгд л сонссон гэв.

–Чи эд нарт биш надад илтгэх ёстой, эхээ мартсан эргүү!

–Би чинь танайд алба хаадаггүй байх аа, танд ямар нэг юм илтгэж байх албагүй.

–Муу хорт могой тийм бий, хорлон сүйтгэгч! хэмээн Иван Парфёновичийн уур шатаж, – Сүүний машин хэмхэлчихээд одоо болохлоор авгай хүүхнүүд рүү чихнэ гэнэ ээ! гэж хашгичив.

–Та надтай яагаад ингэж ярьж байна?!

–Юу гэнэ ээ! Чамтай ингэж ярьж болохгүй юм уу? Муу хараал идсэн троцкист! Чи хэний өмнө зогсож байна! гээд Иван Парфёнович нударга зангидав.

–Би нэг мунхагийн өмнө л зогсож байна, ойлгов уу? хэмээн Саша Иван Парфёновичийн нүүр өөд хямсайн хараад, –Мунхагийн өмнө шүү, сайн тогтоож аваарай гэв.

Тэгээд тэр даруй эргээд явчихав. Иван Парфёнович араас нь нэг юм хэлсэн боловч чухам юу хэлснийг Саша сонссонгүй.

Яг тэр өдрийн орой Сашагийн байшин руу морин тэргээр ирж, түүнээс нэгэн танихгүй эр харайж буугаад Сашад нэгэн зурвас өгөв. “Зах. цөлөгдөгч А. П. Панкратовг. Энэ зурвасыг авмагц ДЯАКТ-ын Кежмагийн районы бүрэн эрхт төлөөлөгч нөхөр Алфёров дээр Кежма тосгонд ирэх хэрэгтэй” гэсэн Алфёровын гарын үсэгтэй зурвас байв. Элдвээр татлаагүй нэлээд боловсон гарын үсэг.

Алфёров өөрөө ч гэсэн боловсон хүн шиг Сашад санагдав. Ийм боловсон хүн дөнгөж районы бүрэн эрхт төлөөлөгч байгаа нь хачирхмаар. Өнгөрсөн удаа Сашаг анх ирэхэд тэрээр бас өнөөдрийнх шигээ энгийн хувцастай байсан учир чухам ямар цолтой нь тодорхойгүй байв.

Тэрээр суудаг байрандаа албаа явуулж албан тасалгаа нь байшингийнх нь үүдэн талын тэн хагасыг эзэлнэ. Гэхдээ Сашаг айлд ирсэн хүн шиг цэлгэр зайтай зочны өрөөндөө хүлээж авав. Тэр өрөөнөөс нэг хаалга албан тасалгаа руу, нэг хаалга унтлагын бяцхан өрөө рүү, бас нэг хаалга гал тогоо руу гардаг ажээ. Тэр сүүлчийн хаалганаас сэрүү татаж буй нь цаашаа хашаа руу гардаг үүд тэнд байгаа хэрэг.

–Панкратов, суу. Шинэ газар хэр тохижиж байна? хэмээн Алфёров ширээний хажууд буй сандал руу зааснаа, өөрөө нөгөө талд нь тухлан сууж хөгжүүн уриалгахан байх нь жаахан юм балгачихсан юм уу гэж Сашад санагджээ.

–Төвхнөсөөн.

–Боломжийн байр, боломжийн улс таарсан уу?

–Дажгүй.

–Сайн байна, маш сайн байна...

Алфёров ширээний дээр дүүжлээстэй байгаа дэнлүүний шилэн бүрхүүлийг авч дэнг асаан тохируулаад бүрхүүлийг буцааж углав. Зочны өрөөний булангууд сүүдэртэн ширээ гэрэлтэн тодроход тэнд нэг хуудас цаас байгааг үзээд өөрийг нь ховлосон бичиг гэдгийг Саша тэр даруй гадарлав.

–За, тэгэхлээр бүх юм сайн сайхан байгаа байж хэмээн Алфёров суудалдаа буурьтай суух зуур өгүүлснээ, –Тэр маш сайн байна... Харин энэ бол муу шүү, Панкратов гээд ширээн дээр байгаа цаас руу зааж, –Таны талаар гомдол мэдүүлсэн байна, зориуд хорлон сүйтгэж, тосгоны ганц сүүний машиныг эвдсэн гэнэ, яг хорлон сүйтгэж гэж бичсэн байна шүү. Юу хэлмээр байна? гэж асуув.

–Би сүүний машин эвдээгүй, харин гурван ч удаа цэвэрлэж өгсөн, цэвэрлэхийн тулд задалдаг

юм, тэр бол яггүй хэцүү ажил. Би эхний удаа задлахдаа л голных нь эрчлээс элэгдчихсэн, түүнд угладаг эм эрэг удаан барихгүй, сүүний машиныг МТС руу аваачиж шинэ эрчлээс татуулах хэрэгтэй юм байна гэж мэдсэн юм. Аль ч механикч, аль ч засварчин үүнийг нотолно. Би энэ тухай тэдэнд тэр дор нь хэлсэн, тэгээд сүүлд хоёр дахь, гурав дахь удаа задлахдаа бас тухай бүр дахин хэлж байсан. Тийм учраас надад буруу байхгүй. Тухайн үед МТС руу аваачаагүй улс л буруутай. Би тосгоноос гарах эрхгүй болохоор өөрөө аваачих арга байгаагүй гэж Саша хариулав.

Алфёров түүнийг анхааралтай сонсох зуур хэд хэдэн удаа суудлаа засан улам эвлэн тухалж Сашаг цаанаа л нэг янзтай харна. Бодвол хоолон дээрээ ганц хундага юм татсан бололтой, зав ихтэйг ч хэлэх үү, яриа дэлгэх дуран дээрээ байв.

–За тийм байж. Тэгэхлээр та анх задлахдаа л элэгдсэнийг үзсэн байх нь. Би зөв ойлгож уу?

–Зөв ойлгосон байна. Би тэр даруй хэлсэн...

–Тэр яахав. Тийм эрчлээстэй аппарат хэрэг байхгүй гэдгийг ямар ч механикч, ямар ч засварчин нотолно гэж баталж байгаа.

–Мэдээж нотолно.

–Панкратов, тэгэхлээр ийм байна. Эрчлээсийг сая эвдэлсэн гэдгийг механикч нотолно. Сая гэдгийг давтан хэлье. Харин сарын өмнө таныг анх удаа задлахад эрчлээс эвдэрсэн гэдгийг ямар ч механикч нотлохгүй. Түүнээс гадна иргэн Панкратов эм эргийг хазгай эрэгдэж байгаад эрчлээсийг эвдэлсэн байж болох уу? гэж механикчаас асуувал яах вэ? Юу гэж хариулах бол? Нээрэн, тэгсэн ч байж болно, эм эргээ буруу оруулж түлхүүрээр огцомхон эргүүлээд эрчлээсийг нь идүүлчихсэн байж болно гэж хэлнэ. Би авцалдаатай ярьж байна уу?

–Үгүй, авцалдаагүй байна гэж Саша өчив.

–Тийм үү? хэмээн Алфёров гайхаж, –Би уул нь өөрийгөө юмны учир олохдоо яггүй гэж тооцдог юмсан. Миний ярьж байгаа юмны юу нь авцалдаагүй байна, Панкратов аа?

–Би сүүний машиныг анх задалмагцаа МТС-д аваачиж шинэ эрчлээс гаргах хэрэгтэй гэж тэр дор нь хэлсэн.

–Хэнд хэлсэн гэж?

–Тэнд байсан бүх хүнд.

–Тэнд чинь хэн байсан юм бэ?

–Авгайчуул, хамтралын хүүхнүүд, хориод хүн байсан.

Алфёров түүн рүү хөгжилтэй нүдээр харна.

–Панкратов, та чинь боловсролтой, ухаантай хүн шүү дээ! Та тэд нарт хэлж л дээ, гэтэл таны

бодлоор бол тэд нар яах ёстой байсан бэ?

–Хамтралынхаа даргад мэдэгдэх ёстой.

–Панкратов! Тэд нар чинь бичиг үсэггүй авгайчуул, эрчлээс, эм эрэг, гол гэхчлэнгийн үгийг насандаа сонсоогүй улс. Тийм үгийг хэлж ч чадахгүй. Тэд нар хамтралынхаа даргад юу ч хэлж зүрхлэхгүй, цаадах нь хүний явдалд бүү оролц гээд хэлчихнэ. Ер нь өөрснөө ч гэсэн тэр аппаратыг нь битгий аваад явчихаасай гэцгээж байгаа, нэг аваад явчихвал буцааж авчирч өгөхгүй, харин байж байхдаа бол ажиллаад болоод л байна гэж бодож байгаа. Даргад та л хэлэх ёстой байсан, гэтэл хэлсэнгүй, түүнээс болоод аппарат эвдэрчихсэн байна. Одоо утга авцалдааны тухайд юу гэмээр байна?

–Гойд юм алга.

–Тийм үү? Яагаад?

–Би хамтралд алба хаадаг хүн биш, сүүний машин зассан гэж мөнгө аваагүй, зүгээр л хүмүүст тус больё гэж санасан юм. Би тэр аппаратыг хэмхэлсэн үү, үгүй юу? гэдэг л ганц асуулт байна. Би эхнийхээ задаргааг хийнгүүтээ л аппарат эвдэрсэн байгааг нийтэд зарласан юм чинь би эвдлээгүй гэсэн үг. Миний тэгж хэлсэн гэдгийг бүгдээрээ нотолно.

Алфёров түүн рүү жуумалзан харж байснаа санаад оромгүй аяархан, бүр гунигтай ч гэмээр дуугаар,

–Нээрэн нотлох юм биз дээ? гэв.

–Тэд яахаараа нотлохгүй байх билээ? гэж Саша итгэл муутайхан хариулах зуур өөрийнх нь байдал тийм ч туйлбартай биш гэдгийг даруй ухаарч эхлэв.

–Ээ Панкратов, Панкратов, та чинь яасан гэнэн хүн бэ гэж Алфёров түрүүчийн адил аяархан гунигтай өгүүлээд, — Москвад хаахнуур аж төрдөг байсан бэ? гэв.

–Арбагад.

–Тэгвэл та бид хоёр хөршүүд юм байна гэж Алфёров бодол болон өгүүлсэн боловч өөрийнх нь Москвагийн байр хаа байдгийг хэлэлгүй, -Нээрэн Панкратов, та ч мөн гэнэн хүн юм аа. Тэр авгайчуудыг шүүхэд дуудлаа гэж саная, та төсөөлж байна уу? Нэгдүгээрт, та тэдний нэр овгийг хэлж чадах уу? Бараг үгүй биз. Хоёрдугаарт, тэд шүүхээс ухаан жолоогүй айна, тийм учраас тийшээ очихоос элдэв аргаар зайлсхийнэ. Хэрэв заяа шүүх дээр хоёр гурван авгай олоод ирж дөнгөдөг юм гэхэд тэд бид юу ч мэдэхгүй, сонссон юм огт байхгүй, үзсэн харсан ч зүйлгүй гээд ганцхан юм үглээд сууцгаачихна. Жингийн нэг тавган дээр цөлөгдсөн эсэргүү та байна, нөгөө тавган дээр нь хамтралын дарга байна, тэр бол эрх мэдэл, хүч чадалтай, тэдний хувь заяаны эзэн хүн. Тэд хэний гэрч болох вэ? Панкратов, та дээгүүр сэвэхээ больж өөрийнхөө байдлыг зөв үнэлж үз. Танд нэг ч гэрч байхгүй. Гэтэл хамтралын даргад бол бүх тосгоноороо гэрч болно. Тийм болохоор таныг хөдөө аж ахуйн техник зориуд эвдсэн өөрөөр хэлбэл хорлон сүйтгэх ажил хийсэн гэж үзэх үндэс прокурорт бүрэн байна. Та мэдээжээр

сонин уншиж байгаа биз дээ? гэв.

–Би одоо хэр хэвлэл авахгүй байгаа.

–Тэгвэл Москвад уншиж байсан шүү дээ. Хараа биз дээ? Хаа сайгүй хорлон сүйтгэх үйл ажиллагаа байгаа. Трактор, комбайн, цайруулагч, хадагч машин энэ тэрийг энд тэндгүй хорлон сүйтгэж эвддэг. Энэ чухамдаа тийм үү? Зориуд эвдэлж байна уу? Хэн эвдэлж байна? Хамтралчид уу? Яах гэж тэр вэ? Ингээд үзэхэд бидэнд өөр гарах газар алга. Манай хөдөөгийн харчуулын хэдэн зуун жилийн турш мэддэг ганц техник нь сүх, гэтэл бид тэднийг трактор, комбайн, автомашин дээр шууд гаргаж байна. Тэгээд тэд мэдэхгүй чадахгүйгээсээ болоод техникийн болон бусад эрдэм номгүйгээсээ болоод нөгөө машин техникээ эвдэлж байна. Бид яах ёстой вэ? Тосгон тэр аяараа техникийн боловсролтой болж зуу зуун жилийн хоцрогдлоо даван туулж, хөдөөгийн харчуул олон үеийн турш бүрэлдсэн зан чанараа өөрчлөх хүртэл хүлээх үү? Одоохондоо бол трактор, комбайн, автомашинаа эвдлээд тийм байдлаар юм сурч байг гэж үзэх үү? Маш их цус урсгаж байж олж авсан техникээ эвдэлж устгуулахад нь хүргэж бид чадахгүй. Гэтэл хүлээж байж бас чадахгүй, яагаад гэвэл хөрөнгөтөн орнууд биднийг багалзуурдаад бүрэлгэчихнэ. Бидэнд ганцхан арга бий, хүнд бэрх боловч цорын ганцхан арга. Тэр бол айдас. Айдас маань “хорлон сүйтгэгч” гэсэн үгэнд биеллээ олж байгаа юм. Трактор эвдэлчихлээ гэхэд чи хорлон сүйтгэгч гэсэн үг, тэгээд арван жилийнхээ ялыг авах чинь тэр! Бас хадагч, цайруулагч эвдсэн ч ялгаагүй арван жил. Ингээд өгөхтэйгөө зэрэг манай тариачин эр сая эргэцүүлэн бодож, сая шилээ маажин, трактортойгоо ноцолдож, гадарлах төдий хүнийг үзээд өгөөч, туслаач, аминд орооч хэмээн царайчлан лонх архиа тавьж байгаа юм. Саяхан би нэг өдөр голын эргээр явж байсан чинь нэг банди моторт завин дээр уйлаад сууж байна: “Оосроос нь татчихсан чинь нэг юм тасарчихаад мотор асахаа больчихлоо, одоо таван жил ян гээд буулгачихна даа”. Мотор нь энгийн болхидуу эд, онгойлгоод харсан чинь нэг жижигхэн хөшүүрэг мултарчихсан байна, тэрийг нь бэхлээд өгтөл мотор ч асах нь тэр. Гэтэл тэр хөвгүүнийг чинь мотор эвдэлсэн, загас бэлтгэх төлөвлөгөө тасалдуулсан, бас өөр яасан ч гэдэг юм бэ, хэрэг тулгаад л шүүх байсан шүү дээ. Шүүхийнхэн дээрээсээ тийм заавар чиглэлтэй. Ер нь ч өөр зам алга. Техникээ аварна гэдэг бол аж үйлдвэрээ аварна, улс орноо аварна, ирээдүйгээ аварна гэсэн үг. Өрнөдөд яагаад ингэхгүй байна вэ? Би хариульга. Бид анхныхаа тракторыг 1930 онд гаргалаа, гэтэл өрнөдөд 1830 онд, зуун жилийн өмнө гаргасан, тэд бүхэл бүтэн зуун жилийн туршлагатай, тэнд трактор хувийн өмч болохоор эзэн нь эд хөрөнгөө хайрлаж байна. Гэтэл манайд эд хөрөнгө гэдэг чинь сангийнх, тэгээд л түүнийгээ сангийн аргаар хамгаалахаас өөр аргагүй байна. Бид бараг эрдэм мэдлэггүй тосгоны хөвгүүнд юм чадахгүй байхад нь хорлон сүйтгэгч хэмээн таван жил, аягүй бол арван жил өгч байгаа юм чинь бараг инженер болчихсон цөллөгийн эсэргүүнд хэдэн жилийн ял оноох ёстой вэ? Ямар ч шүүгч танд сэтгэлдээ сэвгүй ял оноох төдийгүй урьдынхаа нүглийг танаар цагаатгаж сэтгэлээ цэвэршээж авна. Нөгөө золгүй муусайн харчуулыг тушаалаар ялласан юмсан, харин энүүнийг бол хэргийнх нь хэмжээгээр яллалаа гэж хэлнэ дээ. Панкратов, та өөрийнхөө байдлыг ойлгохгүй байна даа! Та цөллөгт байгаагаа эрх чөлөөтэй байна гэж бодож байна. Эндүүрч байгаа чинь тэр! Би бүр өөр нэг юм хэлье. Хориход байгаа хүмүүс чинь та нараас дээр байдаг юм. Тийм шүү, тэд нарт хэцүү л дээ, хөр цасны жавраар хүйтэн нойтонд өлөн хоосон мод бэлтгэх хэрэгтэй, өргөст торны цаана байна, гэхдээ эргэн тойронд чинь өөртэй чинь яг адилхан хоригдлууд байгаа, танд бусдаас ялгарах юм байхгүй. Энд бол харуул манаа байхгүй, эргэн тойрон ой хөвч, гол мөрөн, эмнээс өөрцгүй агаар байна, гэхдээ та энд

бол харийн хүн, та энд бол дайсан, танд энд ямар ч эрх мэдэл байхгүй. Ганцхан хов дуулдлаа гэхэд л бид таныг шоронд хийх үүрэгтэй. Таны байгаа айлын эзэгтэй ирээд л нөхөр Сталиныг зүхсэн гэж хэлэг л дээ. Тэгвэл энэ чинь алан хядах явуулгын бэлтгэл гэсэн үг.

Тэрээр Сашаг харан инээмсэглэнэ.

—За Панкратов, нэгдүгээр зүйлийн тухайд байдал ийм байна. Үүгээр бол та дор хаяхад арван жил авна. Панкратов, та намайг ойлгов уу?

—Мэдлээ, би таныг ойлголоо гэж Саша хариулав.

Тэрээр бүх юмыг сайн ойлгож авчээ. Соловейчикийг гэм халгүй шог ярианаас, Ивашкиныг сонины үсгийн алдаанаас, тогоочийг “залхуу шөл” гэсэн үгнээс болж цөлсөн юм чинь, наймдугаар сарын 7-ын өдрийн хуулиар хос улавчны төлөө арван жил оноодог болсон юм чинь, өөрийг нь шал дэмий тайлбар шүлгээс болж цөлсөн юм чинь сүүний машины төлөө, “хөдөө аж ахуйн техникийн” төлөө мэдээж ял хайрлахгүй.

—Сайн байна гэж Алфёров өгүүлээд, -Одоо хоёрдугаар зүйлдээ шилжье. Тэр бол “хамтралын удирдлагын нэр хүндийг гутаасан” явдал. Та хамтралчдын дэргэд даргыг нь мунхаг гэж хэлсэн байна. Тэгж нэрлэсэн үү? гэв.

—Тэгсэн. Гэхдээ тэр намайг түрүүлж муухай зүхээд хорт могой, хорлон сүйтгэгч, троцкист, хувьсгалын эсэргүү, бас өөр юу ч билээ элдвийн муухайгаар дуудсан юм.

—Нээрэн тусгүй юм болжээ хэмээн Алфёров зөвшөөрснөө, — Гэхдээ Панкратов, та тэр даргатай хамт шүүлгэж байна гэж сана. Сүүний машин эвдсэн тухайд таны буруу батлагдсан. Ийм байхад хамтралын ажил үйлсийн төлөө бие сэтгэлээ зориулж яваа хамтралын дарга таныг хорлон сүйтгэгч гэж нэрлэсэн байна. Зөв л хэлсэн байна. Уурандаа цохиод авсан байлаа ч гэсэн шүүгч нар түүнийг ойлгох л байсан. Харин хараал зүхлийн тухайд бол энд хэн ч тоохгүй, хараалын төлөө ял оноодоггүй юм. Таны хувьд гэвэл сүүний машин эвдлээд зогсоогүй, тэр хүнийг олны өмнө мунхаг гэж доромжилсон байна. Гэтэл тэр чинь хамтралын дарга хүн, түүний хүч чадал нэр хүндэндээ байдаг, тэр нэр хүндийг нь та гутаасан байна. Тэр хүн энэ албан тушаалаасаа одоо огцрох хэрэгтэй болно. Танд арван жил заачихтайгаа зэрэг хамтралын даргыг доромжилно гэдэг юу болохыг хамтралчид сая ойлгож түүнийг хүндэлж, үгэнд ий ордог болно. За Панкратов, байдал ийм байна. Та ойлгож байна уу?

—Надад бүх юм ойлгомжтой гэж би түрүүн хэлсэн.

—Чухам юу ойлгосныг чинь сонсмоор байна.

—Би ямар ч эрх мэдэлгүй, намайг яасан ч та нарын дур гэдгийг ойлголоо, хорлон сүйтгэх ажил хийсэн, нэр хүнд гутаасан хэргээр намайг шүүж болно, намайг доромжилж, нүүр лүү минь нулимж болно гэдгийг ойлголоо. Гэхдээ би доромжлолыг доромжлолоор, шүлсийг шүлсээр хариулна гэдгийг та бодолцоорой.

Алфёров түүнийг сонирхон харав.

–Түүнээс гадна та болгоож хайрлавал хорлон сүйтгэх ажлын тухай таны яриад байгаа юмыг би ёс суртахуунд харш зүйл гэж үзэж байна хэмээн Саша үргэлжлүүлэн яриад, –Элдэв алдаа, маш олон алдаа гарч байна гэж хэлж болно, өөрийн биеэр үзлээ. Гэхдээ хорлон сүйтгэх ажил гэдгийг нам, улсын бодлогын арга болгож зохиосон гэдэгт би итгэхгүй, ийм юм байж болно гэж үзвэл намдаа итгэхээ болино гэсэн үг, миний хувьд гэвэл надад тохиолдсон бүх явдлыг эс харгалзан би намдаа итгэсээр байна гэв.

Алфёров түүнийг сонирхон харсан чигээрээ,

–Тэгээд цааш нь? гэв.

-- Би хэлэх юмаа хэлчихлээ.

–За тэгэхлээр хорлон сүйтгэх явдлын онолын тухайд гэвэл боломж гардаг юм бол хоёулаа эргэж ярилцана аа, гайгүй хэмээн Алфёров нухацтай өгүүлээд, — Та намдаа итгэж байгаа чинь маш сайн байна. Би бүр хувьсгалаас өмнө намд элссэн ахмад большевик хүн, тэгэхлээр намын бодлогыг танаас муугүй мэдэх байх. Гэвч бид одоо энэ тухай яриагүй, таны тухай ярьж байна, таныг хэрхэхээ би шийдэх ёстой болоод байна. Та намайг таныг манагч, таныг дарлагч хүн байгаа мэт харж байна. Би таныг харгалзаж байгаа нь мэдээж, энэ бол миний үүрэгт багтдаг зүйл. Гэтэл би бас таныг хариуцаж байгаа хүн, таны зан байдал, тэгж ярих юм бол таны аюулгүй байдлыг хүртэл хариуцаж байгаа хүн. Та Богучаныд тэндхийн бүрэн эрхт төлөөлөгч Барановтой уулзсан уу? Тэр годилыг харав уу? Хэрвээ тэр миний оронд байсансан бол та аль хэзээний Канскийн шоронд орчихсон, ялаа хүлээж байх байсан юм. Харин би бол Баранов биш, та бодвол анзаарсан байх. Тантай ярилцаж байна. Яагаад ингэж ярилцаад байна вэ? Уйдсандаа тэр үү? Зарим талаар тийм, түүнийг үгүйсгэхгүй. Гэхдээ зөвхөн зарим талаар шүү. Хамгийн гол нь би шийдвэр гаргах ёстой. Би гаргахгүй бол өөр хүмүүс гаргана, тэгвэл танд л муу болох юм. Ямар ч атугай давын өмнө таныг Мозговаас холдуулах ёстой болж байна, таныг Мозгонад үлдээнэ гэдэг бол таныг зөвтгөж, хамтралын даргыг буруутгана гэсэн үг, тэгэх юм бол таныг шинэ мөргөлдөөнд оруулах аюул бий болгоно гэсэн үг. Хамтралын дарга энэ сүүний машинтай зүйрлэхийн аргагүй хэрэг танд тохоож өгнө. Юу хэлмээр байна даа, Панкратов оо? гэв.

Шинэ газар очиж дахиад л бүх юмаа эхнээс нь эхлэх болох нь. Дасчихаад байгаа Зида, үерхэж эхэлсэн Всеволод Сергеевич хоёрыг орхих нь, дахиад л хаягаа өөрчлөх нь, эхлээд Канск, дараа нь Богучаны, дараа нь Кежма, дараа нь Мозгова, одоо дахиад бас нэг газар. Ээж маань юу гэж бодох вэ?... Их муухай юм болох нь дээ... Нөгөө талаас Алфёровын хэлдэг зөв. Мозгонад цаашид байх нь зохисгүй юм. Иван Парфёнович яаж ч мэднэ. Гэтэл Алфёров яагаад өөрөө шийдэхгүй байна вэ? Яагаад өөрөөс нь асууж байна вэ?

–Би арваас доошгүй жил авна гэдгийг та маш үнэмшилтэй нотолж өглөө. Хаа хүлээзнэх нь надад ямар ялгаа байх сан билээ? Бодвол нэг их удаан хүлээхгүй байлгүй, тэгэхлээр Мозговадаа хүлээсэн минь дээр биз гэж Саша өчив.

Алфёров толгой сэгсрэв.

–Удах, удахгүйг яаж мэдэх вэ дээ... Би Канскт асуудал тавиад тэнд шийд гаргавал зөндөө

хугацаа өнгөрч болно, гэтэл есөн сард зам хаагдана, тэгэхлээр хариу бүр өвөл болсон хойно, хагас жилийн дараа ирнэ гэсэн үг.

Энэ юу гэж толгой эргүүлээд байна вэ? Юу бодож олсон юм бол? Энэ чинь хэнээс ч зөвшөөрөл авах ёсгүй шүү дээ. Тэгье гэх юм бол хорлон сүйтгэх ажил хийсэн гэж хэрэг тулгаад маргааш гэхэд л Канск руу явуулчихаж чадах ёстой, ийм эрхтэй юм чинь. Энэ хүн өөрөөс нь юу хүсээд байна вэ?

—Та дураараа бол л доо, тэртэй тэргүй та өөрийнхөө санаснаар л хийх юм чинь.

Алфёров босож шүүгээ рүү очиж галуун хүзүүттэй бараан өнгийн шингэнээс нэг хундагалж уучихаад Саша руу эргэж,

—Ганц хундага уухгүй юу? Естой сайхан дарс гэв.

—Баярлалаа, үгүй.

—Балгадаггүй юу?

—Энэнээс арай өөр байдалд бол яахав.

—Тэр чинь зөв шүү, толгойд гарчихвал хэлэхгүй юм хэлж гарын үсэг зурахгүй юман дээр зурчихаж мэднэ.

Алфёров дахин нэг хундага дарс хөнтрөөд нэг хоёр жимс ам руугаа шидэж үмхэв.

—Сайхан дарс хэмээн давтан өгүүлээд, — Манай айлын эзэгтэй ойн нэг жимсээр исгэдэг юм. Тэгээд ялангуяа эр хүнд их ашигтай гэдэг юм. Та залуу хүн болохоор танд хамаагүй хэрэг, над шиг настай хүн бол бодолцохоос аргагүй болох юм.

Тэрээр ширээ рүүгээ буцаж ирэв.

—За Панкратов минь, одоо тэгээд яах вэ?

—Намайг Канск руу явуулчих л даа, тэгээд л гүйцээ биш үү. Эртхэн орвол эртхэн гарна гэдэг цэцэн үг цөллөгийнхөнд бий.

Алфёров энэ тоглоом болгосон үгийг нь тоосонгүй.

—Панкратов минь, чи сүүний машин эвдлээгүй гэдгийг би мэднэ, тийм учраас танд арван жилийн ял өгсөн хэрэгт ормооргүй байна. Ер нь ч би яарахгүй байж чадна. Нээрэн шүү! Өргөдөл байж л байна, түүний дагуу хэзээ ч ажилласан болно.

Тэрээр дахин инээмсэглэв. Тэгснээ босож өрөөн дундуураа явж, яггүй хүйтэн сэнгэнэж байгаа гал тогооны хаалгыг сайн хаагаад буцаж ирж суунгаа,

—Мозгова руугаа буц. Гэхдээ “мунхаг” гэж хэлснийг хамтралын дарга өршөөхгүй гэдгийг

бодоорой. Ямаршуухан байхаа эргэцүүлэн бод, элдэв сайхан юм горьдохын хэрэггүй, ямар ч хүнтэй бүү сөргөлд гэж тун нухацтай хэлэв.

Түүний дууны өнгөнөөс ямар нэгэн хүнлэг чанар Саша анзаарсан боловч ямар ч атугай уярч арганд нь орж болохгүй гэж бодов.

–Тэгвэл би ерөөсөө гадагшаа гарахгүй байх юм болов уу?

–Гарах нь аюултай байвал гарахгүй бай л даа.

–Тэгээд би юугаараа амь зуух билээ?

–Төрөл төрөгсөд чинь танд мөнгө гуйвуулдаггүй юм уу?

–Гуйвуулдаг. Гэхдээ ээжийн маань цалин хариугүй цөөхөн, угаалгын газар ажилладаг юм. Эцэг маань аль хэзээний биднээс тусдаа гарчихсан.

–Муу хэрэг байна, гэвч надад танд туслах юм даанч алга. Танаас бусад цөллөгийнхөн яаж ийгээд учраа олцгоогоод л байх юм. Ер нь бол цөллөг энд таарахаа больсон зүйл, хамтрал байгуулахаас өмнө цөллөгийнхөн хувийн аж ахуйнтныд ажиллаж болдог байх үеэс тэр чигээрээ хоцорсон юм. Бодвоос эндхийн цөллөгийг мөд устгаж, хот руу шилжүүлж таарна. Ингэхэд та чинь ямар мэргэжилтэй билээ?

–Намайг тээврийн дээд сургуулийн сүүлчийн курсээс барьсан юм.

–МТС-д очмоор юм байна даа гэж Алфёров бодлогошрон өгүүлэв.

–Би хөдөө аж ахуйн техник мэдэхгүй л дээ. Алфёров дахиад гэнэтхэн инээд алдав.

–Хөдөө аж ахуйн техник мэдэхгүй хэрнээ сүүний машин засах гэсэн байх нь. Тэгсэн мөртлөө намайг учир авцалдаагүй юм ярьж байна гэж буруушаагаад байгаа. Би философич байсан хүн учраас эгдүүцсэндээ ийм юм ярьж байна. Харин энд бол ямар юмных нь техник байх вэ дээ? Араа, эрэг хоёрыг ялгаж чаддаг бол техникийн мэргэжилтэн гэсэн үг. Манай МТС-ын захирал засварчин, ерөнхий механикч нь тракторчин. Та бол автомашин мэддэг юм чинь тракторын учрыг олж чадна. Таныг ирэх үед би мэргэжлийг чинь мэдэхгүй байсан юм, түүнээс биш Кежмад үлдээчих байж л дээ. Ямар яльгүй юмнаас таны хувь заяа хамаарч байгааг хараа биз дээ, тэр үед би асуух ухаанаа олсон бол та өдийд районы төвд суугаад МТС-д ажиллаж байхгүй сэн үү... За тэр ч яахав, бид энэ тухай эргэж яримз, харин нөгөө хэргээ дуусгах хэрэгтэй хэмээн тэрээр Иван Парфёновичийн өргөдөл рүү зааснаа, –Мозгова руугаа буцаж оч, гэхдээ болгоомжтой байхыг буюу одоо цагийн ярьдгаар сонор сэрэмжтэй байхыг давган сануулья гэв.

Тэр хоёр шөнийн харанхуй гудамж руу гарав.

–Таны нөгөө тэрэг чинь яваад өгчээ. Буцааж аваачих хэрэгцээ гарахгүй гэж шийдсэн бололтой гэж Алфёров өгүүлэв.

–Зүгээр, явган яваад хүрчихнэ.

–Харанхуй шөнө тайга дундуур арван хоёр километр... Айхгүй байна уу?

–Үгүй ээ, баавгай шөнө унтаад өгдөг шүү дээ.

–Эсвэл хоноод яв л даа, зэрэгцээ байшинд манай эзэгтэйн эгч байдаг юм, таныг аяыг нь олоод хонуулчихна гэж Алфёров санал болгов.

–Үгүй ээ, баярлалаа, хэрэггүй.

Варя, Костя хоёр Крымээс эргэж ирээд Софья Александровнагийн суух болов. Тэднийд сууж байсан нөгөө авгай тэр үед бүр явчихсан тул өрөө нь суларсан юм байжээ.

Варя хүнтэй суусныг Софья Александровна одоо яая гэх вэ дээ, бас нэгэн хүн Сашагаас холдлоо хэмээн сэтгэл хатамжин тэвчив. Сашагийн бүх найз нар түүнийг мартжээ. Вадим, Лена Будягина энэ тэрийн хэн нь ч утасдахгүй, хэн нь ч асууж лавлахгүй юм, Юра Шарокийн тухай бол ярихын ч хэрэг алга, тэрээр Софья Александровнатай мэндийн зөрөөгүй байдаг юм чинь. Нина Ивановна эхний үеэс орж гардаг байснаа одоо Варя, Костя хоёрыг гэртээ хоргодуулсны учир Софья Александровнаг зориуд үл тоомсорлон тэднийхээр үзэгдэхээ больжээ. Үнэнийг хэлэхэд түүний ирэхээ больсонд Софья Александровна чухамдаа баяртай байжээ. Нина эхлээд Сашагийн баривчлагдсаныг утга учиргүй алдааны харгай гэж ярьдаг байснаа сүүлдээ улс орны дотоод болон олон улсын байдал нарийн төвөгтэй байна, ангийн тэмцэл хурцдаж байна, намын эсрэг бүлэглэлүүд идэвхжиж байна, одоо байр суурь хэзээ хэзээнээс илэрхий тодорхой байх шаардлагатай, гэтэл харамсалтай нь Саша заримдаа аливаа юм, үйл явдлын тухай өөрийнхөө ойлголтыг хамт олны үзэл бодлоос дээгүүр тавьдаг байсан гэхчлэн арай өөр өнгө аястай зүйл ярьдаг болсон юм. Нэг үгээр хэлбэл Сашагийн хэрэгт татагдсаныг битүүдээ үндэстэй гэж байгаа нь тэр.

Харин ганцхан Варя л Софья Александровнаг орхисонгүй, тэгэхлээр Сашаг бас орхиогүй гэсэн үг. Саша тэр хоёрын хооронд болсон юм байхгүй, тэгсэн мөртлөө ч өөртэй нь хамт шоронгийн оочерт зогсож эргэлтийн юмнаас бэлтгэлцэж угаалгын газрын зарим бүдүүлэг үйлчлүүлэгчдээс түүнийг өмөөрч, ийнхүү ганц бие хүний зовлонг хуваалцаж байгаа билээ. Гэхдээ зөвхөн өөрийг нь өрөвдсөндөө ч ингэж байгаа юм биш. Үүний цаана Саша байгаа, түүний тухай бодсон, түүний хувь заяаны төлөө санаа зовсондоо тэр.

Гэвч яая гэх вэ дээ. Амьдрал бол амьдрал л юм хойно. Софья Александровна Варяд эхийн ёсоор хандаж, гагцхүү сайн сайхныг л хүсэж байгаа. Уул нь эрт л хүнтэй суулаа, аз жаргалтай л явах байгаа даа? Костя сул гартай өгөөмөр залуу, ресторанаас элдэв амттай юм авчирна, нэг удаа зөндөө том бялуу авчирч Софья Александровнад өгөхөд нь удвал муудчих учраас тэрээр яахаа мэдэхгүй байснаа хэд хуваагаад эгч дүү хоёртоо аваачиж билээ. Бас эмэгтэй хүний нусны алчуурын цуглуулга, урт оймс гэхчлэнгийн элдэв дэл сул юм бэлэглэнэ, тэр ч байтугай нэг шүхэр бэлэглэсэн. Софья Александровна хэдийгээр тухай бүр авахаасаа татгалздаг боловч түүний өгөөмөр сэтгэлийг бодохоос авахгүй байхын аргагүй болдог байжээ.

Тэглээ ч гэсэн Софья Александровна Костягийн тухай бодохдоо сэтгэл нь түгшээд болж өгөх биш. Ажил хийдэг газар байхгүй, одоо цагт ийм байж таарах уу? Чийдэнгийн шилэнд түрхэх ямар нэгэн хольц зохион бүтээж түүндээ зохиогчийн эрх аваад татвар төлж, санхүүгийн байцаагчтай харьцдаг юм гэж Варя ярьсан. Энэ бүхэн Эдийн засгийн шинэ бодлогын үе эргэж ирсэн мэт нэг л хачин сонсогдоно. “ЭЗШБ-ын хүн”, “ЭЗШ бодлоготнууд” гэсэн үг өөрийнх нь хувьд дамаар баяжих, өнгө мөнгө хөөцөлдөх, панз үсэргэх гэсэн утгатай ойлгогдоно. Тэгтэл тэр улирч өнгөрсөн хорвоогийн хүн дахин гарч ирдэг байна. Хаа ч ажил хийхгүй, утсаар үл ойлгогдох юм ярина, хачирхмаар дэгжин хувцаслана. “ЭЗШ бодлоготнууд” л яг тэгж хувцасладаг байсан билээ. Тэгээд Софья Александровна хөдөлмөрчин айлын охин

Варя өөртөө харш орчинд уруу татагдан орсонд харамсан сууна. Костя орой болгон ресторанд орно, Варя бол орой болгон биш юм гэхэд бямба, ням гаригт заавал. Костяг бильярд тоглодог гэж Варя өөрт нь үнэнийг хэлсэн удаатай, тэгэхлээр тэр нь л чухамдаа гол орлого нь байж таарна, нөгөө чийдэнгийн шил, түрхэх хольц энэ тэр гэдэг бол Костя хууль ёсны орлогоор аж төрж байгаа мэт түүний байдлыг хуудуугүй болгох гэсэн зохиомол зүйл. Үнэн хэрэгтээ бол мөрийтэй тоглоомчин, рестораны бильярдчин байх нь, тэгээд л үүрээр эргэж ирдэг хэрэг. Түүнд гадуур хаалганыхаа түлхүүрийг өгөхөөс өөр аргагүй болж саадгүй оруулахын тулд айлын хүмүүсийг унтсаны дараа хаалганыхаа гинжийг мулталж байхыг Варяд зааж өгсөн. Энэ бол байрны хаалгыг шөнийн цагт заавал гинжилдэг олон жилээр хэвшсэн дүрмийг зөрчсөн хэрэг юм. Гэвч өөр арга байхгүй, хаалганы гинж дүүжлээстэй байвал Костяд хонхдох хэрэг гарна.

Нэг удаа Варя гинжээ мултлахаа мартчихаад унтаад өгчээ. Костя өглөөний дөрвөн цагт ирж хонх дараад бүгдээрэнг нь сэрээчихжээ. Михаил Юрьевич тэсээд дуугарсангүй, харин хөрш хүүхэн Галя “элдэв юмнууд харанхуй шөнөөр сэлгүүцээд унтуулахгүй юм” гэж хашгичжээ.

Галя Сашагийн өрөөнд санаархаж байжээ. Тэрээр өөрөө нөхөр хүүхдийнхээ хамт арван дөрөвхөн ам метр талбайд аж төрж байхад Софья Александровна өөртөө хэрэггүй, илүү өрөөгөө бусдад хөлслүүлж орон сууцаар дам хийж байна гэж үзнэ. Галя тэдний харьцааг өөчлөн хооронд нь муутгахыг хичээж, хууль зөрчиж байгааг нь хэрүүл шуугиан дэгдээн мэдэгдэж тийнхүү тэр өрөөг нь салгаж авах санаатай. Софья Александровна үүнээс санаа зовно. Уул нь энэ өрөө Павел Николаевичийн нөөц байр гэдгээр Москва хотын захиргаанд бүртгэлтэй, түүнээс гадна тэр өрөөнд нь Варя сууж байгаа нь хэнд ч падгүй л дээ! Варя энэ байшинд бүртгэлтэй, тэгээд ч залуухан, нөхөртэй хүн чинь яаж эгчтэйгээ нэг өрөөнд унтацгаах билээ! Софья Александровна тэр хоёрыг сул өрөөндөө түр байхыг зөвшөөрч байгаа, энэ бол хэнд ч хүртээлгүй хэрэг! Гэвч Костяг яах вэ? Варя түүнийг Сокольникт Москвагийн нэг районд бүртгэлтэй гэсэн, тэр нь үнэн болов уу? Гэтэл Варягийн нөхрөөс паспортыг нь үзнэ гэж шаардах эвгүй байдаг. Хэрвээ Галя цагдаа дуудаад шалгуултал Костяд Москвад суух зөвшөөрөл байхгүй байвал яана? Софья Александровна хэдийгээр Варягийн сэтгэлийг зовоомооргүй байсан боловч түүнтэй ярилцахаар шийджээ. Төдөлгүй нэг шалтаг гарав.

Варягийн бие төдгүй байв. Костя түүнийг гар хуруугаа муухай болгож гал тогооны үнэр ханхлуулж байхыг хүсдэггүй, хоол унд хийхийг зөвшөөрдөггүй учир ресторанаас давхар саванд үдийн хоол авчрах болжээ. Ер нь тун үнэтэй хоол авчирна. Тэгэхдээ Варяд төдийгүй Софья Александровнад бас авчирна.

Авчирсан хоолыг голдуу Варя халаадаг боловч энэ удаа Софья Александровна өөрөө халаахаар болжээ.

Тэрээр тугалын давтамал махыг хайруулын тавганд хийхүйд рестораны амтлаг хоолны үнэр гал тогооны өрөөгөөр тархав.

Галя хямсалзан,

—Үгүй, яасан сайхан үнэр вэ... Шүлс гоожиж байна гэж өгүүлэв.

Софья Александровна түүний егөж байгааг ойлгоогүй дүр үзүүлэн,

–Варя өвчтэй байгаа, Константин Фёдорович ресторанаас авчирсан юм гэж хэлэв.

–Баячуудын хоол ч сайхан юм аа, бидэнд ч сагамхай загаснаас өөр юм олдох биш. Тэднүүсийн хоол бодвол найман рублиэс наашгүй, аягүй бол бүр бүхэл аравт хүрдэг юм байгаа биз... гэж Галя мөн хямсалзав.

–Энэ хоол ямар үнэтэй байдгийг би мэдэхгүй гэж Софья Александровна тоомжиргүй хариулаад буруу харав.

–Хүмүүс ер нь мөнгө хаанаас олдог байна аа? Шөнөөр ажиллаад байх юм, манаач юм уу, хаашаа юм бэ? Гэтэл манаач чинь хашааны цэвэрлэгчээс бага авдаг шүү дээ гээд Галя салах янзгүй.

–Галя больж үз, би танаас гуйя, та чинь сайхан санаатай сайн хүүхэн шүү дээ, ингэж байхын хэрэг юу байна? гэж Софья Александровна өчлөө.

–Одоо ч сайхан санаатай улсыг л ноолдог болжээ хэмээн Галя хорон өгүүлээд,

- Тийм хүмүүсээр одоо газар хагалж, ус зөөж байна. Сайн санаатай хүмүүс өдрийн хагасжин оочерт зогсоод тасалбараа бараа болгож чадахгүй байна, трамвайнд бол гишгүүр дээр нь л зогсоогоороо явж байна, аягүй бол ойчоод дугуйн доогуур нь орчихно, гэтэл янзын санаатай улс нь таксигаар давхилдаад л ресторанаас толгой цухуйлгахгүй байх юм гэв.

Софья Александровна юм ч хэлэлгүй, хоолоо өрөө рүүгээ авч оров. Гэтэл түүний байдлыг Варя анзаарчээ.

–Софья Александровна, та яасан уруу царайтай байх юм бэ?

–Галя сая гал тогоонд баячуудын хоол, ресторанаас салдаггүй, өглөөгүүр гэртээ ирдэг гэхчлэнгийн юм яриад...

–Түүнд ямар хамаа байна?

–Атаархаж байгаа юм байлгүй...

–Муу новш! гэж Варя зүхэв.

–Аягүй бол Сашагийн өрөөг эзэгнэх гэж байж ч магадгүй.

–Таны байр баталгаатай юм чинь.

–Намайг энэ өрөөг дамлаж байна гээд баталчих юм бол надаас хураагаад авчихна гэж бодож байгаа юм.

–Та Галягаас айдаг юм уу?

–Би түүнээс айхгүй, гэхдээ энэ хэрүүл шуугиан...

–Муу шулам! гэж Варя зүхээд, –Би гайгүй үзүүлээд өгнө өө, доржноо дуугаа татах вий, тэр муу гэв.

–Варенька минь, тэгэхийн хэрэггүй, цаадах чинь гай тарьж чадна шүү.

–Тэр надад ямар гай тарих юм бэ, мэдэх юмсан!

–Чамд биш гэхэд Константин Фёдоровичид тарина.

–Тэр юу юм бэ, хулгайч уу, луйварчин уу?

–Варя, чи юу гэж дэмий ярина вэ? Гэхдээ тэр чинь тодорхойгүй байдалтай хүн гэдгийг чи үгүйсгэхгүй биз. Хаа ч ажилгүй, ямар ч албагүй шүү дээ.

–Үгүй, артельд алба хаадаг юм гэж Варя зөрөөд, — Харин бильярд тоглохын тухайд бол улсын бильярдаар тоглож байгаа юм. Энэ чинь хэнд ч хориглоогүй зүйл гэв.

–Варенька, надад Константин Фёдоровичид дургүйцэх юм юу ч байхгүй. Гэхдээ түүний энд бүртгэлгүй байгааг Галя ашиглаж мэднэ.

–Би ч гэсэн танайд бүртгэлгүй шүү дээ.

–Гэхдээ чи бол энэ байшинд бүртгэлтэй.

–Тэгвэл Костя өөр байшинд бүртгэлтэй, ямар ялгаа байна?

–Цаадхыгаа Москвад суух зөвшөөрөлтэй гэж чи сайн мэдэж байна уу?

–Тэгэлгүй яахав!

Энэ эрсхэн хариуны цаана итгэл байна гэдгийг Софья Александровна мэдэрсэнгүй. Гэвч Варя тэр зөвшөөрлийг нь өөрийнхөө нүдээр харсан эсэхийг асууж зүрхэлсэнгүй. Гагцхүү,

–Бас та хоёрын харьцаа бүртгэлгүй байгаа гэж хэлэв.

Варя жумалзасхийв.

–Манай оронд нийлсэн хоёрыг албан ёсны гэр бүлтэй адилтгаж үздэг. Бид дундын хөрөнгөтэй, нэг ор дэвсгэртэй, авгай нөхөр хоёр.

–Варя, чи юу ярьж байна вэ?! хэмээн Софья Александровнагийн нүүр нь үрчийв.

–Юу хэлчих шиг болов? Би саяхан нэг шүүхийн хурал дээр орж үзсэн юм, хүүхдийн тэтгэврийн тухай хэргийг шүүж байсан. Шүүгч шууд л дундын хөрөнгөтэй байсан уу? Нэг ор дэрэн дээр унтаж байсан уу? гэж асуусан.

Софья Александровна дахиад үрчийв.

–Софья Александровна, хэрвээ биднийг гэртээ байлгахад эвгүй байгаа бол та шуудхан хэлчихээрэй. Та айж байгаа юм уу? гэж Варя үнэнээсээ өгүүлэв.

–Та нар өөрийн гэсэн өрөөтэй болж хүний дайтай төвхнөтлөө манайд байцгааж л бай. Харин элдэв зохисгүй явдал гарахгүй байхаар бүх юмыг зохицуулж байх хэрэгтэй. Чи үүнийг зөвшөөрч байна уу? гэж Софья Александровна бас үнэнээсээ хэлэв.

–Би зөвшөөрч байна, тэгээд бодож үзье.

–Варенька, бас нэг юм байна. Би танай өрөөнд буу байхыг үзсэн, зүгээр ч үгүй хоёр шүү.

–Тэр чинь ангийн буунууд. Костя анчин хүн.

–Тэгсэн ч гэсэн дээ. Чи намайг ойлгох ёстой. Арбат бол тусгай дэглэмтэй гудамж, би ийм байдалтай байгаа хүн яаж гэртээ буу байлгах билээ, одоо чинь ийм юманд маш ширүүн шүү дээ. Константин Фёдорович өөрийнхөө гэрт ийм юмтай байгаасан бол өөрөө л хариуцалгүй яахав, харин манай байранд бол би л хариуцна хэмээн Софья Александровна нэлээд шаардсан янзтай өгүүлэв.

Тэгээд хэсэг зуур чимээгүй байснаа,

–Би энэ өрөөг Сашадаа хадгалж үлдэх ёстой, энэ бол Сашагийн өрөө, энэ өрөөнд халдах аливаа аюул, бүр хамгийн өчүүхэн аюулыг ч гэсэн би зайлуулж байх үүрэгтэй гэж нэмж хэлэв.

–За мэдлээ, үүнээс хойш энд буу байхаа болино гэж Варя өчив.

Костягийн Москвад суух зөвшөөрлийг Варя өөрийнхөө нүдээр үзээгүй. Крымд зочид буудалд орохдоо Костя түүний паспорттай хамт өөрийнхийгөө үзүүлж маягт бөглөхдөө хаягаа Москва гээд л цааш нь бичиж байсан. Өөрөөр хэлбэл паспортандаа байгаа юмыг л бичээ шүү дээ, буудлын бүртгэгч хүүхэн шалгадаг юм чинь.

Тэгсэн ч гэсэн Варя Костягийн паспортыг гардан барьж үзсэн удаа байхгүй. Тэгэхлээр өөрөө эндүүрсэн байвал яана, цаадах нь “Москва” гэж бичээгүй, өөр хотын нэр бичиж байсан бол яана? Өөрт нь ч хамаа алга л даа, харин Софья Александровнад гай тарьж болохгүй. Тэрээр яг тэр оройдоо Костяд,

–Софья Александровна чиний зөвшөөрлийн тухай санаа зовж байгаа юм байна гэж хэлэв.

–Би хаана суух зөвшөөрөлтэйгөө түүнд хэлсэн шүү дээ, итгэхгүй байгаа юм уу, хаашаа юм бэ?

–Итгэж байгаа. Харин энэ Галя гэдэг хөрш хүүхэн хов жив хөөцөлдөж энэ өрөөг нь салгаж авах санаатай, Софья Александровнаг орон сууц дамлаж байна гэж хаа сайгүй хашгичаад яваа юм байна. Тэгэхлээр чамд Москвад суух зөвшөөрөл байхгүй байвал Софья Александровнад гайтай юм болно.

–Түүнд паспортаа үзүүлэх хэрэг үү?

–Тэгвэл л бүр сайн.

–Хэзээ үзүүлэх юм бэ? Намайг ирэхэд унтаж байх юм, сэрэхэд яваад өгсөн байх юм чинь.

–Надад орхичих, би үзүүлчихье.

Тэрээр Варя руу хялайв.

–Би паспортаа орхиж болохгүй, надад хэрэгтэй байдаг юм. Намайг маргааш эрт сэрээгээрэй, би өөрөө үзүүлье.

–Бас нэг юм байна. Софья Александровна гэртээ буу битгий авчирч байгаач гэж гуйсан.

–Үгүй энэ чинь ангийн буу, хориогүй буу шүү дээ.

–Тэгсэн ч гэсэн болохгүй, Галя энэ тухай хов хүргэж мэднэ.

–Надад зөвшөөрлийн бичиг бий гэдгийг хэлээрэй.

–Зөвшөөрөл ганцхан буунд өгдөг, гэтэл чамд хэд хэдэн буу байна.

–Ангийн буу чинь хууль ёсны эд, Софья Александровна толгойгоо бүү зовоог гэж Костя уцаарлав.

–Чи бид хоёрт энд ганцхан хууль бий. Тэр бол Софья Александровна, энэ гэрийн эзэгтэй. Нэг бол бид түүний шаардлагад захирагдана, нэг бол эндээс тонилох ёстой болно гэж Варя хэллээ.

–За яахав, та нарынхаар болог хэмээн Костя дурамжхан өгүүлэв.

Эрт босож заншаагүй болохоор маргааш өглөө нь эвшээлгэн суниасаар өндийж халаад нөмрөн пиджакныхаа халааснаас паспортаа авч Софья Александровнагийн хаалгыг тогшиж орсноо төдөлгүй буцаж ирэв.

–Жин тан болгочихлоо. Тэгээд дахиад хэвтээд өгөв.

Костя Варяд паспортаа бариулж үзүүлээгүй, Варя үүнийг цаагуураа мэдсэн боловч энэ тухай бодохыг эс хүснэ. Варя Костятай толгой холбосон ахархан хугацаанд цаадхыгаа хэцүү хувь тавилантай, бэрх байдалд байгаа хүн, тийм учраас элдэв юм түүнээс шалгаахын хэрэггүй. Нэг хэлэхгүй гэсэн юмаа хэзээ ч хэлэхгүй хэмээн ийм байдалтай нэгэнт эвлэрчээ. Эцэг эх нь гэж Азовын тэнгисийн загасчин. Оросжсон грекүүд байсан агаад хөрөнгөө хураалгаж Мариуполиос цөлөгдсөн ажээ. Костя тэгэхэд худалдааны флотын усан цэргийн хувьд гадаадад явж байсан учир эцэг эхийнхээ тэр хувийг амссангүй. Тэрээр аяллаас буцаж ирмэгц ар гэрийнхнийхээ цөлөгдсөнийг мэдээд Пирей буюу Стамбулд үлдээгүйдээ харамсаж байснаа Варяд нэг удаа илэн далангүй хэлсэн аж. Тэгсэн бол одоо тэнд зугаацаж явахгүй юу.

Үүнээс хойш флот руу очихоо больсон. Гадаадад явж байгаа хүнийг нарийн шалгадаг учраас эцэг эх нь хөрөнгөө хураалгасан гэдгийг олж мэдээд өөрийг нь мөн цөлчихнө гэж айгаад тэр. Тэрээр нийслэлд мөр буруулахад амар хэмээн Москвад ирж монтёр хийх зэргээр ажил сольж явсаар түрхэх хольц зохион бүтээж, артельд орсон боловч гол ажил нь бильярд болжээ. Москвагийн толгой бильярдчин Бейлис Костяг анзаарч бэлжүү хөдөөгийнхөн буюу сангийн мөнгөтэй томилолтынхны мөнгийг хуу хождог гол гол бильярдын газруудаар явуулж сургажээ. Костя тэднийг ёстой хайр найргүй хожно. Эхлээд амархан хожигдчихоод дараа нь хамаг юмыг нь нүцгэртэл нь мулзалж өгнө.

Костя Америкт аж төрдөг байсан бол саятан болох байсан гэж Лёвочка хэлсэн удаа бий. Америкт зөвхөн гутал цэвэрлэгч төдийгүй бас гэмт хэрэгтнүүд ч гэсэн саятан болдог гэж Ика доогтой өгүүлж асан. Варя дүрсхийн улалзаж Икад амаа хамхиж явсан нь дээр гэж зөвлөсөн. Гэхдээ Костяд тэр яриаг дамжуулаагүй, тэгсэн бол Икагийн гутал цэвэрлэгч гэж хэлснийг нь Костя өршөөхгүй байсан юм.

Варя Костятай сууснаар бүх шат дамжлагыг алгасаж Вика Марасевич, Нина Шереметьева, Ноэми энэ тэрээс дээгүүр гараад иржээ. Тэд нар нь нөгөө явдаг улсынхаа аяыг дагадаг бол мань хүн нөхөртэйгөө ресторанд орно. Нөхрийг нь мэдэхгүй хүн байхгүй, цөм түүнийг бялдуучилна. Түүнээс гадна охидуудын өөр хоорондоо дам дам худалддаг гадаадын элдэв өмсгөлд Варя үл атаархана. Костя түүнийг Москвагийн хамгийн шилдэг үйлчин, гуталчин, үслэг эдлэлийн оёдолчнуудаар оруулжээ. Түүний пальтог Лавров, даашинзыг Надежда Петровна Ламанова, Александра Сергеевна Лямина, Варвара Степановна Данилова, тэр ч байтугай Ефимова, хөхний даруулгыг Лубенец, оймсны татуургыг Арбатын Кошке, бүрх малгайг Тамара Томасовна Амирова, өндөр өсгийтийг Барковский, Гутманович, Душкин энэ тэр урлан хийнэ. Костя хямдхан үйлчдийг үл тоомсорлож Москвагийн хамгийн үнэтэй оёдолчин Журкевичээр өөртөө костюм хийлгэнэ.

Ингээд үзэхэд өнгөнөөс харвал бүх юм баяр хөөртэй, гял цал оргиж байгаа мэт. Гэвч Костя тэр хоёрын холбоо хэврэгхэн зүйл гэдгийг Варя мэдээд байлаа. Яагаад тэр вэ? Тэрээр өөрөө ч эс мэднэ. Урьдах амьдралынхаа олон юмыг голдог байсан боловч юм болгон ойлгомжтой тодорхой асан билээ. Одоо бол тийм тодорхой байдал байхгүй, тэрээр хаашаа хийсэж, хаашаа хөвж яваагаа үл мэднэ. Костя өөрөөс нь бараг арав ах, тэгсэн хэрнээ уншсан ном гэж нэг ч байхгүй, тэр ч байтугай “Шадар гурван цэргийг” ч уншаагүй. Пушкины бүх зохиолоос “Бильярдын цохиураар зэвсэглэсэн битүү тооцоотой нэгэн эр хар өглөөнөөс авахуулаад хоёр бөмбөлгөөр наадна” гэдэг дөрөвхөн мөр л мэднэ. Гэхдээ мань хүн ухаан сэргэлэн, энэ хэдэн мөрийг Пушкин өөрт нь харш бус гэдгийг харуулах гэсэн дээ биш, харин Пушкинд яг өөр шиг нь бильярд харш зүйл биш байсныг харуулах гэсэндээ тийн иш татдаг болой. Варя түүнд хайртай билүү? Хэлэхэд хэцүү. Нөгөө юм Ялтын зочид буу-далд тохиолджээ. Тэрээр охидуудын яриад байдаг нөгөө үзээгүй юмыг амсах гэсэн хүслээсээ болсон уу, эсвэл жинхэнэ ёсоор хүүхэн болох гэсэн хүслээсээ болсон ч байж магадгүй, ямар ч атугай эсэргүүцээгүй.

Гэвч үүний дараа ч гэсэн салж хагацахын аргагүй болтол ойртоогүй, тэр хоёрыг нэг л юм тусгаарлаад байлаа. Ээ дээ насны л ялгаа болов уу?.. Костя усанд сайхан сэлнэ, тэглээ ч гэсэн өргөн цээжтэй, богинохон хөлтэй (энэ нь костюманд овоо засагдана), гар хөл, нуруу нь нэл үсэнд баригдчихсан, цээжин дээрээ бүргэд шивсэн бахимхан тэрбээр нүцгэн байхдаа

өөрөөсөө хамаагүй ахимаг харагдаж түүнтэй хамт далайн хөвөөнөө нарлаж усанд ороход Варяд нэг л хачин санагдана... Тэр хоёр буудалдаа буцаж ирэхэд цаадах нь хаалгаа цоожилж байгаад тэврэн авч хүзүү цээжгүй үнсэлж үнгэнэ. Гэтэл Варя гэрлээс бишүүрхэхийн зэрэгцээ ресторанд орохоор буухад нь хүн амьтан өөрийнх нь царайгаар сая тэгсэн юм байна гэж мэдчихнэ хэмээн айж зовно. Унтахаар хэвтэхдээ Костягийн нүдэн дээр тайчихаасаа ичиж гэрлээ унтраана. Түүнийг энхрийлж тэвэрч үнсэж барихаасаа бас ичнэ. Ер нь тэгэх дур ч эс хүрнэ.

Энэ шинэ амьдралд ухаан жолоо алдан амь тавих юм байсангүй. Уул нь мөрөөслөөс цаашгүй мэт санагдаж байсан юмс гэнэтхэн гарт орж ирж, хэзээ язаанаасаа ингэж л аж төрж яваа юм шиг ердийн зүйл болжээ. Үдшийн рестораны баяр ёслолын байдал урьдын адил сэтгэл татаж гоёлын хувцаснууд сайхан санагдавч хийлгэх гэж зөндөө удаан хэмжин сонжуулахаас залхаж, оёдолчны шийдгүй байдалд уцаар хөдлөн, үсчин Полийнд Москвагийн хүүхнүүдийн хамаг сор цугладаг ч гэсэн тэнд цөхрөн хүлээж суухаас дургүй нь хүрнэ.

Үсчний газар Арбатад “Прага” рестораны хажууд байдаг билээ. Костя тухайн үедээ эднийд үс хатаах чийдэн тавьж өгсөн учраас Варя бусад байнга үйлчлүүлдэг хүүхнүүдийн адил хашаан дотроос үсчний гэрийг дамжин ордог болжээ. Харин үсчин Польш буюу Павел Михайлович Кондратьев, тэдний авгай хумс засагч Вера Николаевна хоёр яагаад ч юм бэ, Варяг онцгойлон үзнэ. Тэр үед зургаан сар тогтдог буржийлга гойд маяг байсан боловч Павел Михайлович,

–Ийм царайг нүднээс гартал муухай болгож болох уу даа! гээд Варяд хийж өгөхөөс татгалзжээ.

Үсээ буржийлгахгаар хүлээж байсан хүүхнүүд үүнийг сонсчихоод доромжлуулсандаа мэдээж гомдоцгоожээ. Гэвч Варя үүнийг юман чинээд тоосонгүй! Тэрээр өөрийн гэсэн танилуудтай, өөрийн гэсэн найзуудтай юм чинь. Тэр нь нөгөө Костягийн бүлэг. Тэд нар ресторанд орохдоо хуучин янзаар нэгэн ширээнд сууцгааж, Варя ч гагцхүү тэдэнтэйгээ л бүжиглэнэ. Костя хаа нэг түр зуурхан бильярддын өрөөнөөс гарч ирж хундага архи тогтоож юмханаар даруулсан болоод энэ хөөрхөн хүүхэн миний авгай, энэ залуус бол миний бүлэг, өөрийнх нь мөнгөөр идэж ууцгааж байна гэдгийг олон түмэнд үнэмшүүлэх гэсэн мэт Варяг мөрөөр нь энхрийлэн тэвэрнэ. Лёвочкад үнэтэй оёдолчноор явах сачий лав байхгүй биз, тэгэхлээр Костягийн мөнгөөр бас хувцасладаг байх гэж Варя боддог билээ. Гэвч Лёвочка бол бильярд тоглодоггүй, дарс бараг уудаггүй, эелдэг даруу, анхаарал болгоомжтой зантай, нэмэрт нь ажилд махруу, жирийн нэгэн шугам зурагчин, ямар ч өөгүй банди. Костяд шударга түвшин ариун цагаан гэргий хэрэгтэйн адил Москвагийн сайн айлуудын боловсон залуусаас бүрдсэн чухам ийм бүлэг бас хэрэгтэй юм. Энэ бол түүний нүүр царай, түүний нийгэмд эзэлж буй байр суурь, түүний өөрийгөө харах толь. Тэрээр юу ч уншихгүй хэрнээ бусдын юу уншиж байгаа, ямар зохиолч одоо шуугиулж байгаа, ямар нь нэр цуутай энэ тэрийг андахгүй мэднэ. Сэргэлэн ухаан, овжин овсгоотой, дүлий годил шиг царайлах дургүй, хүний нэр ус тогтоохдоо сайн.

Нэг удаа ширээнд сууцгааж байтал Ика асуулт хариултын уралдаан явуулж байгаа мэт дуугаар,

–Хийсэн хоёр кино нь “О”-гоор эхэлдэг, найдвар төрүүлж байгаа найруулагч. Овог нь хэн бэ?

гэж асуужээ.

Костя Икагийн харцыг ажиглаж амжаад эргэж харангуут хоромхон зуур,

–Барнет гэж хариулжээ.

Костя бүгчим газар байж сууж чаддаггүй, кинонд дургүй, дагшаа концерт, хошин дуурь, бүжгэн жүжгийг илүү үздэг. Барнетийн киног үзээгүй боловч Икагийн асуултад хамгийн түрүүнд хариулсан юм. Тэгээд Барнет руу нөхөрсгөөр толгой дохиод,

–Хамт ан хийж байсан юм гэж хээвнэг өгүүлжээ.

–Өө тийм, би саналаа. Та хоёр чоно алсан нэг явдлыг чи бидэнд ярьж байсан юм байна гэж Ика доогтой тосгуулан авав.

–Тэр чинь энэ биш Качалов, бас чоно биш чонын сүрэг хэмээн Костя уруулаа тамшаалан хариулаад, –Чонын үүрэн дээр яваад орчихсон юм, эхлээд азарган чоныг, дараа нь гичийг нь буудаж алсан, тэгээд гурван бэлтрэг барьж авсан юм. Чи бодвол чоно үзээ биз дээ? Үзээгүй бол Амьтны хүрээлэнд очиж үз, харин илэх илбэх гэж оролдохын хэрэггүй шүү, гаргүй болно гэж мэдээрэй гэв.

Тэрээр дахин нэг хундага архи ууснаа Варя руу налж,

–Гэтэл чи намайг буу байлгалаа гэж зэмлэж байгаа. Харин эднүүс гээд танхимын бүх хүнийг тойруулан зааж, –надтай анд явахын тулд юугаа ч өгөхөд бэлэн байгаа. Ляленька минь, маргааш Урлагийн мастеруудын клубт очъё, тэнд намайг яаж зулгуйдахыг хараарай гэж аяархан хэлэв.

–Тэнд чинь зөвхөн жүжигчдийг оруулдаг биз дээ? Костя үнэн сэтгэлээсээ гайхаж,

–Чи намайг үнэмшихгүй байна уу? Ляленька минь, маргааш тийшээ заавал явцгаая гэв.

Костя маргааш нь Варяд биеэ янзлах, хувцсаа тохируулахад нь туслахын тулд гэртээ эрт ирэв. Варя эхлээд хуниастай захтай, хуниастай банзалтай хөх торгон костюмаа, дараа нь алтан саагаар хээлсэн пүүсүүн саарал хантаазаа өмсөж үзэв. Үүнтэй хамт хагалаатай нарийхан банзал өмсөх ёстой. Эцэст нь задгай энгэртэй хүрэн даашинзаа өмсөж үзлээ. Ажил явдлын тухайд догшин ширүүн байдаг Костя өөрийнх нь гоёлыг хичнээн удаан ч хамаагүй шохоорхон, нүд салгахгүй харж, хүүхэд шиг бөөн баяр хөөр болж буйд Варя үнэнхүү гайхна.

–Естой догь, Ляленька, ёстой ганган байна. Варя Костягийн үнэлгээнд итгэдэг ч гэсэн тэндхийн алдар цуутнууд түүнийг гагцхүү өрөвдөсхийн хүлцэнгүй харьцвал яах вэ! Мань эр тэдний хувьд хэн билээ? Бильярдчин. Одоо бас анчин болж таарлаа. Тэгэхлээр өөрөө анчны хүүхэн юм чинь нэг их гоёчихлоор тэнэг юм шиг харагдах биз.

Түүний тэгж болгоомжилсон нь талаар хэрэг байжээ.

–Клубт алдартай алдаргүй янз бүрийн хүмүүс цугларч жүжигчин өөр хоорондоо эрх тэгш

гэдгийг цохох үүднээс хүн болгон бие биеэ сайн мэддэг дүр гаргацгаана. Тэнд бильярдын хоёр ч ширээ байв. Костя бараг тоглосонгүй. Тэрээр бильярдын нэртэй шүүгч өөрийн танил Захар Ивановичтай цуг зогсоод тоглож байгаа хүмүүст зөвлөгөө өгөн биечлэн тоглохдоо хүрвэл нэр цуутай найз нараа гомдоохгүйн тулд жижигхэн тоотойгоос нь шилж цохино. Костя Старо-Пимений гудамд очихоороо ажил явдлаасаа хөндийрөн амарч зан нь хөгжүүн дөлгөөн байдаг учраас Варя түүнтэй хамт тийшээ явах дуртай.

Клуб хуучин ноёны эдлэн дотор эртний тохилог тавилгатай доод давхарт байрласан ажээ. Хоёр хажуугаараа арваад хүн байрлахаар задгай лоожтой. Заримдаа Костя Лёвочка, Рина хоёрыг бас дагуулж ирнэ. Тэгвэл тэд нар дөрвөн хүний тусгай ширээнд сууцгаана. Харин лоожнуудад бол олуулаа яваа улс сууна. Костя түүнд Ильинский, Климов хоёрыг зааж үзүүлсэнд Варя тэднийг “Гурван саяын хэрэг” гэдэг кинонд үзсэн болохоор дор нь танив. Бас жүжигчин Смирнов-Сокольскийг танилаа. Тэр жүжигчин “Эрмитажийн” тавцан дээр олонтаа тоглодог юм. Смирнов-Сокольский сахалтай халзан хүн рүү жишисхийж суугаад бусад хүнд дуулгахгүй гэсэн юм уу, эсвэл юм гуйж байгаа юм уу, гараараа амаа хорголон нэг юм ярьж харагдана. Цатгалан мууртай төстэй халзан эр зальжин бөлцгөр нүдээ онийлгон чимээгүй сууна.

—Энэ чинь Демьян Бедный гэж Костя хэлэв.

Варяд энд сайхан санагдана. Архи дарсаар үйлчлэхгүй гагцхүү рашаан, жимсний ундаагаар дайлдгийг “Рашааныг хундагаар өгөхгүй” гэсэн зарлал илтгэнэ. Харин гал тогоо сайтай, ёстой амт төгөлдөр хоол хийнэ. Рестораны эрхлэгч нь Москвагийн шилдэг тогооч Яков Данилович Розенталь. Түүнийг зүгээр л Сахал гэгцгээнэ.

Энэ байгууллагын зөв шинжийг илтгэх мэт ханан дээр нь:

Эгэл үнэнийг тогтоож ав.

Энэ клубт авгайтайгаа ир.

Хөрөнгөтнийг бүү дуурай.

Хүний биш өөрийнхөө авгайтай ир

гэсэн бичиг дурайна.

Эхний хоёр мөрийг зохиолч Третьяков, сүүлийн хоёр мөрийн Маяковский өөд болохоосоо өмнөхөн бичсэн гэж Рина нотолно.

Рина энд Костягаас дутахгүй олон танилтай байв. Тэрээр хүнтэй нийцтэй болохоор хэнтэй ч хэл амаа ололцохын хамт ойртуулахгүй гэсэн хүнээ хөндий байлгаж бас чадна. Варя түүний тухай олигтой мэдэх юм байхгүй, лав л Остоженкад Зачатьевын хийдээс холгүй модон байшинд суудаг, “Байшин маань хэзээ л бол хэзээ нурчихаж мэднэ” гэж хөхрөөд хэнийг ч гэртээ урьж залах нь үгүй. Рина тэд наргүйгээр клубт ирдэг боловч чухам хэнтэй ирж, хэнтэй явдгийг тэд хэзээ ч үзээгүй ажээ. Зочид хотын театруудын жүжиг дууссаны дараа

арван нэгэн цагийн үеэр цугларч өглөөний хоёр, гурван цагт тарцгаана. Морин тэрэгчид шөнөжин хөндлөн гудамнуудаар тэднийг хүлээж байдаг билээ.

–Чи хүргүүлэх үү? гэж Костя Ринагаас асууна.

Цаадах нь аальгүйтэн цайвар сормуусаа дэрвэгнүүлж,

–Намайг хүн хүргэж өгч байгаа... хэмээнэ.

Костя Варяг жууз тэргэнд түшиж суулгахуйд тэрээр суудлыг арлан налж тухлан суугаад Старо-Нимений гудмаар Бага Дмитровка руу гарч тэндээсээ цувраа цэцэрлэгт гудамжийг даган явахуйд хот бараг танигдахгүй мэт санагдан, энэ эзэнгүй эл хуль байдал, түнэр харанхуй, нойрсон буй анир чимээгүй байшин энэ тэрд ямар нэгэн түгшүүртэй юм нуугдан байх шиг. Варя өчигдрийнхөө тухай бодон чимээгүй сууна.

Цугларсан хүмүүс ресторанаас дээшээ гарч сайн дурын үзэгдлүүд тоглодог үзэгчдийн танхим руу очих нь элбэг. Жүжигчид өөрснөө элэглэл, бяцхан гараа, шог үзэгдэл бичиж, заримдаа зохиолчид ч энэ ажилд оролцоно, чадварлаг сайн тоглоцгооно, цыганууд дуугаа дуулна, Русланова бас дуулна. Ямар ч театрт ийм юм үзэхгүй шүү дээ. Нэг удаа буурал хөмсөгтэй, буурал сахалтай хүүхэлдэй барьсаар Сергей Образцов тайзан дээр гарч ирсэн. Танхимд цугларагсад алга ташицгаан, Урлагийн удирдах ерөнхий газрын дарга бөгөөд клубийн захиргааны дарга Феликс Коны зуг эргэн харцгааж эхлэв. Хүүхэлдэй тэр хоёр гойд адилхан байжээ. Образцов яг Коны дуугаар “Зөвлөлтийн бүүвэйн дууны тухай” илтгэл уншина гэж зарлав. “Зөвлөлтийн бүүвэйн дуу бол... гээд хүүхэлдэй Коны дуртай зангааг дохиж долоовор хуруугаараа үзэгчдийн танхим руу зааснаа, –хөрөнгөтний дуу биш, манай дуу бол хүүхдийг сэрээх ёстой...” гэв. Гэвч элдэв юм байхгүй, гэм халгүй өнгөрнө. Ер нь энэ хүмүүст баргийн юм зөвшөөрдгийг Варя анзаарчээ.

Гэтэл Костя Клубт долоо хоногт нэгээс илүү орж чадахгүй хэмээж “Мөнгийг энэ клубээс олохгүй гэдгийг чи ойлгож байгаа шүү дээ” гэж хэлжээ. Тэгээд энэ дүрмээ ягштал баримталж байснаа “Эмэгтэй хүний дүр бүтээдэггүй зохиолчдыг шүүсэн нь” гэдгийг найруулж тавих үед цорын ганцхан удаа Варягийн үгэнд орж тийшээ явжээ. Шүүгчид Наталья Сац, яллагдагчдад Катаев, Олеша, Яновский гурав, прокурорт Мейерхольд нар тоглов.

Варя, Костя хоёрын суусан долдугаар эгнээнд Алексей Толстой, зураач Дени, Моор энэ тэр бас сууж таарчээ. Вика Марасевич нүдний буланд үзэгдээд алга болов. Варя түүнийг энд анх удаа үзэж байгаа нь тэр. Харин утга зохиол, театрын шүүмжлэгч болсон Викагийн ах Вадим бол эндээс салдаггүй хүний нэг бөгөөд тэрээр алдар цуутны хавиар чихцэлдэн байдаг ажээ. Мань хүн одоо харалган нүдээ онийлгон сул суудал хайгаад сандлын чөлөөгөөр явж харагдана. Түүний араас, бодвол мань эр л урьсан байх, Юра Шарок, Лена Будягина хоёр явж байна. Лена Варяг таньж толгой эелдэгхэн дохиход араас нь Юра бас харсанд Варя түүнийг үзэж чаддаггүй болохоор тэр даруй хараа буруулав.

Чингэхүйд нөгөө нэг Шинэ жилийг тэмдэглэсэн, Саша, Юра хоёрын хэрэлдсэн энэ тэр санаанд оров. Гэтэл Саша одоо Сибирьт цөллөгт байж байдаг, харин Юра, Вадим, Лена Будягина, Вика Марасевич нар энэ сайхан клубт хөгжилдөж байдаг байна.

Варя бодлогоширч байгаад Наталья Сацын юу хэлснийг сонссонгүй. “Яллагдагсдыг” дуудаж эхлэхэд сая учраа олов. Эхлээд Катаев бослоо. Дуу нь гуншаа, чихэнд чийртэй агаад шуухинаа хүрсэн юм уу гэмээр сэтгэгдэл төрүүлэв. Үзэгчид түүнийг төдий л таашаасангүй, сулхан алга ташицгаав. Яновскийд бас сулхан ташицгаалаа. Харин Олешагийн юм хэлэх болгонд нирхийтэл инээлдэж гарцгаав. Өндөр чацтай ясархаг хамартай Мейерхольд Олеша руу элээ мэт дайрлана. Үс нь хэдэн тийшээ өрвийсөн бие давжаа Олеша хоромхон зуур сөргүүлэн мэд тавина. Варягийн өмнө суусан жүжигчин Ярон сав л хийвэл Алексей Толстой руу эргэн харж, Олеша ямархан байна даа хэмээх мэт хөөрөн нүд ирмэж, аян хамтад нь Варя руу нүдний булангаар сээтэгнэнэ. Тэгээд шүүх хурлын дараа босож Варя руу эгцлэн эргэж хараад гарах хүмүүст саад болон хачирхмаар янзын дүртэй нэг хэсэг гөлрөн зогссоноо “Сайхан хүүхнийг хараад хэрсэн бух шиг хөшчихлөө” гэж дуу алдав. Инээдтэй хэрэг шүү. Варя инээчихэв.

–Та жүжигчин үү? Би яагаад таныг танихгүй байгаа билээ? гэж Ярон асуулаа.

–Би жүжигчин биш, тийм учраас та намайг танихгүй байна гэж Варя жишим ч үгүй хариулав. Инээснийг нь Ярон талархсанд тооцох вий гэж тэрээр болгоомжилжээ.

Энэ бүх алдар цуутантай харьцахад түүнд ярвигтай байжээ. Костя, Рина хоёр инээдмийн жүжигчдийг шагшин магтана. Харин Варя бол тэд инээдмийн жүжигчид учир элдэв юм бурахыг зөвшөөрч байгаа юм гэж бодно. Тэрээр жүжигчдийг жинхэнэ тайзан дээр тоглож байгаагаар нь үзэх дуртай, тийм үед тэдэнд үнэн санаанаасаа баярлан алгаа хорстол ташина. Авьяас гэдэг бол авьяас юмсан хойно. Харин тэдэнтэй танилцах алба байна уу? Яах юм билээ? Костягийн сэтгэлд Варягийн энэ бодол бүрэн нийцэж мань хүн дотроо магнай хагартал баярладаг боловч Зоя, Рина хоёрын аль нэгтэй кинонд явуулахыг эс тооцвол Клуб болон бусад аль ч олон нийтийн газар ганцааранг нь огт явуулахгүй.

Вика Марасевич Урлагийн мастеруудын клубт Юра Шароктой тааралдсанаас болоод дахиж тийшээ явж байхгүй гэж шийджээ. Түүний нүдэнд хэрэгцээгүй өртөж байх уу? Ямар хэрэгтэй билээ? Маросейкад уулзаж байгаа нь болоо. Тэнд уулзахдаа тэдний өдөр тийм ресторанд тийм тийм улс тийм юмны тухай ярилцаад сууж байсан гэхчлэн ээлжит мэдээгээ илтгэдэг билээ. Хүмүүсийн яриа тогтоохын аргагүй шал дэмий юм байдаг ч гэсэн Шарок хүн бүрийн хэлснийг үг үсэгчлэн сэргээж ярихыг шаардана. Вика тэр утгагүй яриаг тогтоодгүй учир зүгээр л юу болсныг мэдээлж гарна...

...Ноэми нөгөө л японтойгоо явсаар байна. Гэтэл нэгэн итали хүн түүнтэй ханилж Итали руугаа авч явах санаатай гэнэ...

...Хоёр шинэ герман хүн гарч ирсэн, тэдэнтэй Метрополь буудлын Сусанна, Катя гэдэг хоёр охин байгаа. Юун германчууд болохыг охидууд ярихгүй байна.

...Хөөрхий Нелли Владимирова нөгөө Поляков гэдэг цыганаасаа салж баян франц худалдаачин Жорж хэмээгчтэй суусан. Том байр, өвч хивс, эртний тавилга, шил шаазан, машин...

Вика Юратай уулздаг уулзалтаа дээдсийн хоосон яриархуу юм болгож хувиргахыг хичээнэ. Оёдолчны хүүд тийм яриа аятайхан санагдах ёстой. Гэвч энэ бүхэн түүнд төдийлөн сонирхолгүй байгааг хүүхэн удалгүй ягшгал ухаарчээ. Шарок түүнийг гадаадынхантай явж байж баригдсан хүн, ямар ч атугай ажиллаж байг... гэж бодоод дотроо түүнээс нэг их онцгой гойд юм хүлээхгүй байгаа байж магадгүй юм.

Үгүй ээ, ямар ч гэсэн нэг юм хүлээгээд л байна... Харин чухам юу юм бол? Бүсгүй түүний үг болгоныг шүүрч өөрийнх нь хэлсэн нэр болгонд хэрхэн хандаж байгааг тогтоож авна... Тэг тэгсээр эцсийн бүлэгт гадарлажээ... Юзик Либерман! Сонирхож байгаа хүн нь тэр байх нь! Тэр том уруултай өндөр залуу бол бүхний мэдэх дээд зэргийн ховчин бөгөөд зөвлөлтийн эсрэг явган шог илэрхий ярьж, яаж ч мэдмээр элдэв тоглоом тохуу хийдэг, гадаадынхныг сонирхдоггүй боловч хариуцлагатай дээгүүр албаны хүмүүсийн дунд хэлхээ холбоо ихтэй (бодвол ээжээрээ дамжиж тэр байх) этгээд юм. Зүгээр ч үгүй хувийн ойр дотнын холбоо шүү. Юра хариуцлагатай ажилтнуудын талаар мэдээ сэлт цуглуулдаг болохоор Юзик Либерман чухамхүү тийм хүмүүстэй холбоотой учраас л түүнд хэрэгтэй байх нь. Тэдний юу ярьж байдаг нь тэгтлээ чухал биш. Бурдаг нь ганцхан Юзик Либерман, гэхдээ мань хүн нийтийн ширээний ард чалчиж бусад нь цөмөөрөө инээлдэж хөхрөлдөн ярианд оролцож байгаа болохоор бүгдээрээ чалчицгааж байгаа гэсэн үг.

Вика энэ тухай ухаармагц Юзикийг бараадах болж, цаадах нь ч түүнийг дуртай дагуулж явах болсноор хүүхэн хэзээ, хэнийд хэнийг үзсэн, юу сонссон тухай дараа нь тодорхой мэдээлэл бичиж эхэлжээ. Шарокт чухам энэ л хэрэгтэй байсан бололтой мэдээллийг нь сонирхон хүлээж авна. Хэдийгээр Вика Юзикийн өөрийнх мэдээлдэг зүйлээс шинэ юм юу ч мэдээлдэггүй байж мэдэвч Шарок чухамхүү ийм зориулгаар өөрийг нь ашиглах ёстой юм байна.

Вика хэдий томоогүй ч гэсэн Юзик Либерманыг бараадах ёстойгоо бодож олсон, Шарокоос түүнд тавьсан зорилтыг тайлж мэдсэн гэдгээ Шарокт харуулахгүй байхаа эрхбиш мэднэ. Тэдний байгууллагад өөрийнхөө үнэ цэнийг нэмэх бодол түүнд огт байсангүй, тэгэхийн оронд Шарокийн нүдэнд дорвитойхон юм шаардахын арга байхгүй, юмны учир мэдэхгүй, богино жолоотой амьтан болж харагдсан нь дээр гэж үзнэ.

Шароктой бачлахдаа Вика гол юмаа түүнээс хамгаалж байжээ. Тэр гол юм нь нэртэй хэдэн уран барилгачдын бүлэг ажээ. Өөрийнх нь хуучин танил Игорь Владимирович гэдэг уран барилгач тэдэнтэй танилцуулж өгсөн юм.

Тэрээр Зөвлөлт Холбоот Улсын Баатар болоод удаагүй алдарт нисгэгчтэй суух мөрөөдөл, тооцоогоо хэдийн орхижээ. Нисгэгчдийг хаанаас олох вэ дээ, түүнээс гадна тэдний муусайн хүүхнүүд юу ч болоогүй шахам байхад л намын хороо, цэргийн командлал, тэр ч атугай бүр Сталин руу алтан хошуу өргөөд харайлгачихна. Салгаж авч чадах юмаа гэж санахад тийм “Баатарт” ямар ч ирээдүй байхгүй, Чукотка руу жирийн нисгэгчээр явуулчихна. Гадаад орон бол хоосон мөрөөдөл. Эрик яалаа? Аятайхан эр гэвч онцгой юм юу ч байхгүй ерийн нэгэн гадаадын хүн. Өдөр бүр усанд орж, сахлаа хусан дотуур хувцсаа сольж, сайхан үнэр ханхлуулна. Түүнээс цааш юу билээ? Гэрлэх тухай ярихаа яарахгүй байгаа, аав ээждээ хэлэхгүйгээр тийм алхам хийхгүй. Фирмийн нэр төр! Аав нь гэж нэг буянтай эцэг их л сайндаа жилийн дараа ирнэ, гэтэл өөрийнх нь нас сүүдэр аль хэдийн хорин дөрөв болчихно.

Викад маш сайхан ирээдүйтэй хүн хэрэгтэй. Тийм хүн бий. Тэр бол томоохон уран барилгач, Москвагийн хамгийн чухал барилга, Сталины унаган бүтээл болж байгаа Зөвлөлүүдийн ордны төсөл зохиогчдын нэг юм. Нас ахимаг биш дөчин гуравтай, залуухан овортой жавхалзсан гоолиг эр, Италид олон жил аж төрсөн тэгэхлээр европ хүн! Тэр хоёр нийлбэл ёстой ховорхон хос гарахсан! Нэг муу савхин гуталтай нисгэгч биш дэлхийд нэр цуутай уран барилгач, тэгээд авгай нь гэж алдартай профессорын охин мань Вика, Москвагийн язгуурын сэхээтэн бүсгүй. Тийм холбоог ямар ч Шарок, ямар ч Дьяков хөндөж зүрхлэхгүй, тэгэх гэж оролдвол тэд мөн ч амархан балрах вий.

Эс тэгвээс нөхөр нь Сталинд “Энэ чинь юу гэсэн үг вэ, Иосиф Виссарионович оо? Надад итгэхгүй байгаа бол намайг өөр хүнээр хянуулж болно биз дээ. Харин манай авгайг албадаж намайг мөрдүүлнэ гэдэг бол ёс суртахуунд харш зүйл” гэж хэлэх болно.

Тэгсэн цагт Дьяков, Шарок мэт нь ёстой бөнжигнөж өгнө дөө. Ажлаасаа танилцгооно, тэд нар шиг ажилтай хүмүүс нэг үсрэхээрээ мөн ч хол үсэрдэгсэн.

Үнэнийг хэлэхэд тэр уран барилгач авгайтай. Авгай нь өөр шиг нь бас Одессийнх, нөхөртэйгөө Италид цуг амьдарч байхдаа тэнд соёлч байдалд дадаж овоо зүгширсэн, хамар нь томдсон, хар үстэй туранхай нэгэн агаад нарийхан урт папирос татаж, ойрын хараа муу хэрнээ шил зүүдэггүй учир нүдээ онийлгон харна. Тэрээр түрүүчийн нөхрийн одоо насанд хүрсэн хоёр хүүхэдтэй. Уран барилгачаас найм ах, тавин нэгтэй, тэгсэн мөртлөө өлөгчин чинь хавьтсан бүхэнтэй энгэр зөрж нөхөртөө тэрсэлнэ. Одоо Коля Крылов гэдэг Москвагийн дүүргийн шар толгойтой хар нялхаараа нэг хөвгүүнийг урхидан намжирдаж, тэр нь цэрэгт явах нас нэгэнт болсон учир авгай түүнийг цэргийн нэгэн эрх дархтаны туслагч болгох санаатай хөөцөлдөж буй болой. Тэрээр нөхөртэйгөө энд тэнд цуг явна гэж огт үгүй, хорин

жилийн хугацаанд хоёр биеэсээ бүрмөсөн уйдсан ажээ. Нөхөр нь урлангийнхаа газар өнждөг төдийгүй заримдаа хононо, бас гадаадад явах нь элбэг тэгэхлээр авгай нь ёстой эрх дураараа байх аж. Уран барилгач Москвагийн дүүрэгт байдаг Сухановогийн уран барилгачдын амралтын газар явахад авгай нь нууц хонгоруудаа гэртээ хонуулна. Цаадах нь ч үүнийг мэддэг болохоор доромжлолоос өөр юм болохгүй хэрүүл шуугиан дэгдэхээс болгоомжлон гэртээ санамсаргүй ирэхээс түдгэлздэг ажээ. Тэр авгай хүүхэн хүний хувьд нөхрийнхөө дурыг татахаа больсныг Вика бат ойлгож авчээ.

Энэ Итали, Одесса хосолсон хүүхнийг гэтлэхэд амаргүй байх вий. Ямар ч атугай харилцаа тогтчихсон, Уран барилгач Викаг шохоорхон хөл алдаж, ор дэрэн дээр нь тэр хоёр олон цагийг бахаа ханган өнгөрөөж буй. Бүсгүй нас залуу, бие бялдар, царай зүс сайхан, сурамгай, туршлагатай, цаадах нь одоо хэр чийрэг, янаг халуун тачаалтай эр. Тэр хоёр бие биеэ харахгүй буюу дор хаяхад утсаар ярихгүй ганц өдөр ч өнгөрөөж эс чадна.

Гэвч хөндлөнгийн хүмүүст энэ харьцаа нууц байгаа билээ. Тэд хүүхний хуучин түншийнх нь хувьд, “дайраад гарсан давааных” нь хувьд гагцхүү Игорь Владимировичийг л мэднэ, түүнийг Новинскийн цэцэрлэгт гудамжнаа орших өмгөөлөгч Плевакогийн өргөө асан одоо Уран барилгачдын ордонд чухамхүү Игорь Владимировичтой очдог гэж мэднэ. Харин элдэв охид тийшээ эс очно. Энэ Ордон хэдийгээр гуравдугаар зэргийнх ч гэсэн өөрийн ресторантай боловч одоо хэр ийшээ гүйлдэх нь маяг болоогүй байгаа билээ. Энд зураг төслийн үзэсгэлэнгүүд л гарна. Даанч тэрийг сонирхох хэн байх вэ дээ?

Ингэхлээр Викад нөгөө явдлаа нуухад бүр ч амар. Тэрээр Уран барилгачдын ордонд гагцхүү Игорь Владимировичтой ирэхэд дараа нь нөгөө Уран барилгач тэр хоёртой нийлнэ. Уран барилгач ийнхүү нууцлахыг илүү зан гэж үздэг боловч Викагийн аялаг занг үнэлэхийн хамт Вика бас түүний оролцдог төсөл хэлэлцэх ажилд сууж маргаан зөрөөнийг анхааралтай сонсдог тул тийнхүү өөрийнх нь ажил үйлсийг сонирхдогийг нь бас үнэлнэ.

Тийм хэлэлцүүлэгт оролцдог ахимаг насны уран барилгач авгай нар Викагийн сэтгэлийг эс зовоовч зураг төслийн газрын дэрэвгэр хүүхнүүд сэтгэл түгшээнэ. Гэвч тэргүүлэх уран барилгач тэгэх тусмаа Ерөнхий уран барилгачдын хувьд эндхийнх нь хүүхнүүд хэрхэвч таарахгүй гэж Игорь Владимирович хэлжээ.

–Материалын эсэргүүцлийн нэгдүгээр хууль ёсоор бол аливаа нэгэн холбоо юмны эрх чөлөөг нэгээр хязгаарладаг хэмээн Игорь Владимирович тоглоом хийж –Гэтэл уран барилгач хүн бол өөрийнхөө урлангийн газар юунаас ч хамаарахгүй байх ёстой гэнэ.

Вика өөрийнхөө дүрд гарамгай тоглож байлаа. Игорь Владимирович хүртэл түүнийг найзад нь сэтгэл алдсан гэж бүрэн итгэжээ. Уран барилгачийн хувьд энэхэн үес бол уран барилгын элдэв урсгал, сургууль, чиглэл, уламжлалын хооронд тэмцэл явж байгаа бэрх үе байжээ. Италид сургууль хийж, олон орноор явж орчин үеийн өрнөдийн уран барилгатай танилцсан сайхь Уран барилгач орчин үеийн ялангуяа өндөр хийцийг тусгасан сонгомол өвийг баримталдаг чиглэлийг тэргүүлдэг аж. Тийм учраас түүнийг олон хүн дайрч довтолдог боловч Вика мань хүнийг суут хүн хэмээж, түүний барилга, төсөл, элдэв санааг мөн суут бүтээл гэж тунхаглан энэ тухай түүний нөхөр, дайсан гэж ялгахгүй бүгдэд ил ярина. Тэр бол суу билэгтэн! Таван зуун жилийн хойно үнэлэгдэх суу билэгтэн биш өнөөдөр байж байгаа,

нийтээр зөвшөөрсөн суу билэгтэн. Түүний гар хүрсэн аливаа юм суут бүтээлүүд!

Нээрэн, энэ нь тун зөв сонгож авсан дүр даруй мөн агаад Вика үнэхээр чадамгай тоглож байлаа. Аугаа их хүнтэй дээд түвшинд харилцаатай байх хэрэгтэй тул Уран барилгачтай зөрнө гэж байхгүй, хэзээ ч маргаж ам муруйхгүй, бас гоморхож тунирхах зан эс гаргана.

–Надад дутагдал их бий хэмээн Вика түүнд учирлаж, –гэхдээ бүсгүй хүний улаан мөнгөний үнэ цэнэгүй өчүүхэн зан надад байхгүй, үүгээрээ би бахархдаг. Чи юу гэж ч бодсон яахав, надтай байхад чамд амар байгаасай, чамд элдэв юм дарамт битгий болоосой л гэж хүсэж байна. Хамгийн гол нь чи тайван байх ёстой гэнэ.

Уран барилгач болзоондоо ирж чадахгүй болчихвол түүнд утсаар мэдэгдэж өрөвдсөн янзтай,

–Чи минь юу хийнэ дээ? гэж асууна. Хүүхэн түүнийг тайтгаруулан,

–Хонгор минь, санаа бүү зов, би жаахан хэвтэж юм уншина. Найз бүсгүй рүүгээ очиж киногоор нэг шүргэнэ. Маргааш өглөө заавал утасдаарай гэнэ.

Вика мэдээжийн хэрэг буйдан дээр хэвтэхгүй, найз руугаа очихгүй, кинонд явахгүй, тэрээр оёдолчин, гуталчин, Юзик Либерман, Шарок энэ тэр гээд өөрийн ажилтай, тэр бүхнээ ёсчлон гүйцэтгэнэ. Өчүүхэн ч тасалдал байж болохгүй. Уран барилгачтай ч гэсэн бас хийдэгдэл байх ёсгүй. Өөрийг нь итгэл төгс үнэнч анд найз гэдгийг мэдэж байг. Ямар ч байлаа гэсэн профессорын охин, ямар ч байлаа гэсэн язгуурт гаралтай хүн! Энд, энэ барлагуудын дунд төрсөн нь өөрийнх ив буруу биш өөрөөр бол сурвалжит бүсгүй, золиг чамайг!

Вика зөвхөн ганц удаа биеэ барьж чадаагүй ажээ.

Зөвлөлүүдийн ордны төслийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдээр Урлагийн музейд үзэсгэлэн гаргасан юм. Музейд өглөөнөөс аваад орой хүртэл олон хүн чихэлдэж Волхонкийн гудамжаар урт оочер хөвөрнө. Уран барилгачид, тэдний дотор гадаадынхан ч бас байгаа, бараг бүгдээрээ авгай нартайгаа өөр өөрсдийнхөө төслийн дэргэд зогсоцгоон төслөө тайлбарлан асуултад хариу өгцгөөнө. Вика ийшээ өдөр болгон ирж Уран барилгачтайгаа уулзана. Тэрээр тэднийхний зүгийн улсаас аль хэдийн олон танилтай болсон болохоор зарим нэг нь түүнийг Уран барилгачийн хувьд хэн болохыг таамагладаг байж ч магадгүй, гэхдээ Вика даруухан янзаараа байлаа.

Амьтны хөл татрахгүй шуугин инээлдэж байвч музейд цорын ганц хүн ерөөсөө ирээгүй нь Уран барилгачийн авгай билээ.

–Түүнийг зүхэхийн хэрэггүй, хорин жил болоход тэр чинь миний төслүүдийг ханатлаа үзэж бүр залхаж хоцорсон юм гэж Уран барилгач өгүүлнэ.

–Гэхдээ энэ бол чиний хамгийн гол төсөл, энэ яваа насны чинь үйл хэрэг чинь шүү дээ!

–Харин төслийг баталж диплом гардуулах үед л тэр чинь хүрээд ирнэ гэж Уран барилгач

ТОГЛООМ ХИЙВ.

–Өө тэгэлгүй дээ! Тэгэхийн цагт тэр чинь чиний дэргэд зогсож чиний ялалтыг хуваалцах болно!

Уран барилгач Викаг анхааралтай харснаа мань хүүхэн өөрөө хамт зогсож, ялалтыг нь өөрөө хуваалцах хүсэлтэй байгаа гэсэн битүү санааг нь ойлгов.

Вика гэндсэнээ тэр даруй ухаарч түүнийг гэмгүй царайлан сугадав.

–Надад горилж байгаа өчүүхэн ч зүйл байхгүй. Гэхдээ чамайг, чиний бүтээлийг ингэж хайхрахгүй байгааг миний хувьд тэсвэрлэхийн арга алга. Гагцхүү ялалтаа харуулж байх үед л чамтай цуг зогсоно гэдэг бол... хэмээн Вика жигшин ярвайж, –Намайг уучлаарай, би чамайг гэнэтхэн өрөвдсөн юм гэв.

Маргааш өглөө нь утасны дуугаар сэрвэл Уран барилгач ярьж байв. Тэрээр, өнөөдөр хаалттай үзлэгтэй учир ирэхийн хэрэггүй, харин утасдахыг хүлээж байгаарай хэмээжээ.

Хаалттай үзлэг гэдэг нь үзэсгэлэнг Сталин болон Засгийн газрын бусад гишүүн үзнэ гэсэн үг.

Вика өдөржин утаснаас хөндийрөлгүй сууж өнжив. Уран барилгач өдрийн сүүл рүү утасдлаа.

–Одоо очлоо.

Тэрээр нэг лонх шампан дарстай ирсэн нь өнөөдөр түүний ялалтын өдөр болсон хэрэг байжээ. Түүний төсөл Сталины сэтгэлд нийцсэн аж.

Өглөө нь тэр хоёр Суханово руу хоёр долоо хоногоор яваад өгчээ.

Сталин Сочийнхоо зуслангийн байрны сэрүүвчинд сүлжмэл сандал дээр нүүрээ наранд ээгээд сууж байв. Тэрээр өөрийн гараар бүтээсэн Сочи хотдоо дуртай, хэдийгээр эмч нар өмнөд нутагт намар явах нь зүйтэй гэж зөвлөдөг боловч мань хүн бас өмнөд нутгийн зунд дуртай. Эмч нар юу мэдэх билээ дээ? Тэрээр хүүхэд ахуйдаа ч гэсэн зун цагт дуртай, Византийн эзэн хаадын байгуулсан Горис-Цихе хэмээх уулан дээрх эртний цайзын нурмал балгас өөд авирч мацах дуртай асан юм чинь. Чухам тэнд ойчиж гараа бэртээсэн билээ. Хэдийгээр Горид тэнгис байхгүй, эндхийнх шиг өвс ургамал байхгүй ч гэсэн Сочи Горийг санагдуулна. Сталины өмнөх ширээн дээр Соловьёв, Ключевский, Покровский нарын ном, референтүүдийн бэлтгэсэн “ЗСБНХУ-ын түүхийн сурах бичгийн товчлолын талаарх санал” энэ тэр байна. Энэ ажлыг Жданов удирдаж байгаа юм.

Түүнийг ӨӨРӨӨ сонгож авсан ажээ. Тэрээр энэ жил Ждановыг Горький хотоос татаж авч Төв Хорооны нарийн бичгийн дарга болгосон юм. Жданов хязгаарыг удирдах ажил, Горькийн автомашины үйлдвэр байгуулах ажлыг амжилттай гүйцэтгэж байснаас болж ингээгүй. Бусад мужийн намын дарга нар ч ажлаа адилхан амжуулж байгаа. Бас Ждановыг дөнгөж гучин наймтай ч гэж тэгээгүй, бусад нарийн бичгийн дарга нар бас өвгөд биш. Хрущёв, Варейкис, Эйхе гурав дөчтэй, Хатаевич дөчин нэгтэй, Кабаков дөчин гуравтай... Харин Жданов бол сэхээтэн хүн, утга зохиол, урлагийн учрыг мэднэ. Гэхдээ бүхнийг мэдэгч Луначарский маягийн сэхээтэн биш, боловсролоороо сагсуурахгүй, гадаад үг хэрэглэж даналзахгүй, Бухарин шиг онолчны зиндаанд байх гэж зүтгэлэхгүй, гэлээ ч гэсэн сэхээтэн. Удирдлагад сэхээтэн хүн хэрэгтэй. Жданов үүнд таарна. Зохиолчдын эвлэл байгуулах талаар түүнд даалгасан анхны томоохон арга хэмжээг овоо бэлтгэж байх шиг байгаа. Зохиолчид бол ард түмний оюун санааны удирдагч болох гэж байнга горилж ирсэн сэхээтний гол отряд учраас удахгүй болох их хурал намаас сэхээтэнтэй харилцах асуудал дээр эргэлтийн цэг болно.

Ленин засгийн эрхийн төлөө тэмцэл хийхдээ сэхээтнийг түшиглэсэн юм. Тэр нь ч зүйтэй байсан, яагаад гэвэл сэхээтэн бол хэзээнээсээ нааш тэрс үзлийг агуулагчид агаад тэрс үзэл гэдэг бол засгийн эрхийн төлөө тэмцэлд сайхан зэвсэг. Гэхдээ засгийн эрхийг нэгэнт гартаа авчихсаны дараа бол сэхээтэнд тулгуурлаж болохгүй, учир нь засгийн зэвсэг бол тэрс үзэл биш нэгдмэл үзэл. Пролетарийн зохиолчдын оросын холбоо (ПЗОХ) мэтийн бүлэглэлүүд сэхээтнийг задлан бутаргаж янз бүрийн үзэл бодол баримтлахаас өөр аргагүй болгож байгаа юм. Үзэл бодлын нэгдлийг хангах байгууллага хэрэгтэй, тэр нь Зохиолчдын эвлэл болох учиртай.

Горький бол зохиолчдыг нэгтгэхэд аятайхан хүн. Мөн чанараараа бол жижиг хөрөнгөтний либерализм руу ихээхэн хэвийсэн зүүн социалдемократ үзэлтэн. Ленин түүнтэй их ноцолдсон, тэгж ноцолдсон нь зөв юм. Горький нэртэй хүн бас өрнөдийн томоохон зохиолчидтой хэлхээ холбоотой. Тэрээр манай олон зүйлийг хүлээж авахгүй байгаа. Гэхдээ цагаачилж явахдаа хилийн чанадад өөрт нь ямар ч ирээдүй байхгүй гэдгийг харсан. Жинхэнэ зохиолч бол эх орондоо аж төрж, эх орондоо өөд болох ёстой. Виктор Гюгогийн хилийн чанадад бичсэн зохиол Францад хэвлэгдэж байсан учраас тэрээр Гуравдугаар Наполеоны мөхлийг гадаадад хүлээх эрхтэй байсан юм. Оросын цагаачдын бичсэн юмыг бид нийтэлдэггүй, цаашид ч нийтлэхгүй, Аркадий Аверченког хэвлэсэн гэнэн явдал давтагдахгүй.

Бунин байна. Юунд хүрсэн билээ? Жаран гурван дээрээ Нобелийн шагнал авсан, энэ хэнд хэрэгтэй юм бэ? Буниныг хэн уншиж байгаа юм бэ? Хэн ч мэдэхгүй нэг амьтан тэр Паристаа л үхнэ, тэд цөмөөрөө тэндээ үхэцгээнэ, оросын утга зохиолд хэн нь ч үлдэхгүй Горький бол үлдэхийг хүсэж байна, эх орондоо хөшөө дурсгалтай байхыг бодож байна. Түүнийг ойлгож болно. Тэгэхлээр тэр хөшөө дурсгалыг нь ч өгнө. Бас зохиолынх нь эмхтгэлийг ч хэвлүүлж өгнө. Бас зохиолынх нь шагналыг ч гадаадын валютаар өгнө. Одоо бол өөрөө биеэрээ валют болчихоод байгаа хүн. Түүнийг өрнөдийн зохиолчид ч хүндэлж, манайхан ч бас хүндэлж, тэр ч байтугай “Серрапионы ах дүүс” дугуйлангийн гишүүд агсан Федин, Тихонов мэтийн авьяаслаг, туршлагатай жинхэнэ зохиолчид хүндэлж байгаа, эд нар бол энэ түрүүнд социализмын үйл хэргийн төлөө зүтгэх ёстой. Гэтэл ПЗОХ тэд нарыг утга зохиолоос нь хөндийрүүлж “пролетарийн” толгой холбогчдыг дөвийлгөн гаргаж тавьж байна. Энэ муусайн толгой холбогчидтой нийлээд юу олох вэ дээ? Тэд нар ТҮҮНИЙ эрин үед утга зохиолын ямар дурсгал үлдээх вэ? Демьян Бедный юу? Демьянаас түүний номын сан л үлдэнэ. Харин ёстой сайхан номын сантай гэсэн шүү. Маяковский чадвартай хүн, шүлгийг нь ашиглах хэрэгтэй, гэхдээ шүлэг гэхээс урьдаар улс төрийн бодлого гэлтэй зүйл дээ.

Дээр үед ӨӨРӨӨ ч гэсэн шүлэг бичих нүгэл хийж байсан. Шашны сургуульд байхдаа “Иверийн” редактор Илья Чавчавазед “Дила” - “Өглөө” гэдэг шүлгээ аваачиж өгсөн. Шашны сургуульд шүлгийг жинхэнэ зохиогчийн нэрээр гаргах хориотой учраас Сосело гэдэг нэрээр бичжээ. Тэгэхэд Чавчавазе түүний Горийн тухай, эцгийнхээ тухай, Атени орох замын тухай, эцгийнхээ найз нартайгаа наргиж байсан тухай дурссан тав билүү зургаан шүлгийг нь нийтэлжээ. Түүнээс хойш МАНЬ ХҮН шүлэг бичээгүй, ийм ажил өөрийнх нь тавилан биш байжээ. Тэр шүлгүүд сайн шүлэг байсан уу? Тэрээр шүлгээ хэзээ ч эргэж уншиж байгаагүй ажээ. Гэвч Илья Чавчавазе түүний “Өглөө” шүлгийг магтаж байсан шиг санагдана...

Улаан сарнайн дэлбээ дэлгэрч

Нил цэцгийг ялдамхан тэвэрлээ.

Үүлэн өндөрт болжмор шулганан

Хавийн газарт дуурсан жиргэлээ.

Тэгээд хорин жилийн дараа 1916 онд Якоб Гогебашвилийн бага сургуульд зориулсан гүрж сурах бичигт «Өглөө» шүлэг нөгөө л Сосело хэмээх зохиогчийн нэрээр орсон билээ. Анх нийтлэгдсэнээс нь хойш хорин жилийн дараа тэр шүлгийг Якоб Гогебашвили сурах бичигт сонгож оруулна гэдэг бол бас ч гэж үнэлж үзэх ямар нэг юм байсан гэсэн үг! Тэглээ ч гэсэн тэрээр яруу найргийн төлөө төрөөгүй, яруу найраг сэтгэлийг уяраадаг учраас яруу найрагч бол тэмцэгч байж чадахгүй. Сэтгүүлчийн ажил бол харин тэмцэлд таарна. Түүний үзэг Хувьсгалын хэрэгт сайн үйлчилсэн юм. Тэрээр их юм бичсэн. Давид, Намеразе, Чижиков, Иванович, Бесошвили, Като, Коба... гэхчлэнгийн олон нууц нэрээр бичсэн. Коба гэдэг нь бүр намынх нь нууц нэр болсон. Тэр нэр өөрт нь аятайхан санагддаг байж л дээ. Коба гэж Казбегийн “Эцгээ алагч” романы шударга ариун үйлстэй баатар. Гэтэл мөн энэ нэрээрээ цагдаагийн газар зар тарчихсан учир бичсэн өгүүллээ ийм нэрээр гаргах боломжгүй болж тэрээр К.Стефин, К.Сталин, К.Солин гэхчлэн дахиад янз янзын нэр хэрэглэх болж, хожим 1913 оны нэгдүгээр сард “Социал-демократ” сонинд шиг билээ дээ, И.Сталин гэдэг нэрийг

гаргах хүртлээ тийнхүү олон нэр ашиглаж байсан юм. Тэгтэл энэ нэр овог нь болж, одоо бүх дэлхий түүнийг энэ нэрээр нь мэдэх болжээ.

Тэрээр шүлэг зохиох ажлыг орхиж зохиолч болоогүй ч гэсэн юм унших дуртай, их ч уншдаг байжээ. Бага залуудаа шохоорхож байсан юмаа хэдийн мартаж, хожмын сонирхолтой нь нэгэнт холилдоод шоронд ч бай, цөллөгт ч бай юм үл уншдаг байлаа. Хувьсгалчийн мэргэжилтэй хүнд юм унших цаг мундахгүй төдийгүй ер нь ийм мэргэжилтэй хүн уншиж байх албатай.

Шашны дунд сургууль сонгодог гимназийн хэмжээний мэдлэг олгоно. Тэнд латин, грек, эртний еврей, франц, англи, герман хэл заана. Гэвч МАНЬ ЭР гадаад хэлэнд хэзээнээсээ авьяасгүй, цөллөгт байхдаа ч гадаад хэл оролдож байгаагүй. Цаг дэмий үрэхээс цаашгүй ажил! Гэхдээ шашны сургуульд таван жил суралцсан бөгөөд хичээл нь орос хэл дээр явдаг байсан болохоор орос хэл сайн эзэмшжээ. Харин бүр бага байхаасаа гүрж аялгатай ярьдаг боловч түүнийгээ засья гэж ер оролдож яваагүй. Аялга бол бага хэрэг. Тэрээр таслал, өргөлт энэ тэрийн алийг нь ч зөв тавьж чадахгүй орос хүнийг үзэхээрээ болсон билээ.

Хоёрдугаар зэргийн, хоёрдугаар шатны зохиолчдын бүтээлийг огт уншихгүй, тэд хэнд хэрэгтэй билээ? Сонгомол зохиолчдыг уншина, энэ бол оросын хувьсгалчид зайлшгүй чухал... Гоголь, Салтыков-Щедрин, Чехов, Горький энэ тэрийг засагтай тэмцэхдээ ашиглаж болно, яриа маргааны үеэр эсрэг этгээдүүд тэд нараас иш татдаг, тэгэхлээр мэдэж байх шаардлагатай! Нөгөө Златовратский, Левитов, Каронин түүнээс гадна Некрасов, Никитин, Суриков мэтийн тариачны зохиолчдод дургүй, тэднийг ер уншихгүй, тэд нар тариачин эрийг өрөвдсөн юм бичдэг гэтэл тариачин эр бол өөрөө хэнийг ч эс өрөвдөнө, үүнийг МАНЬ ХҮН биеэрээ амссан болохоор сайн мэднэ.

Толстой бол томоохон уран бүтээлч, гэвч засгийн мөн чанарыг ойлгоогүй, хүнийг хэтэрхий ариусгахыг хичээж сургаж номнодог, тэгснээрээ бүтээлийнхээ уран сайхныг бууруулж байсан юм. “Оросын хувьсгалын толь” сэхээтэн либералуудад саймсарч юу эс хэлнэ гээч! Достоевский Толстойн нэг адил бас ямар юмны нь гүн ухаантан байх вэ дээ, төр, нийгмийн байгууллын учрыг олдоггүй байсан юм чинь. Гэхдээ Толстойг бодвол хүнийг ариусгаж үзэхгүй, түүний арчаагүй өчүүхэн байдал, өөдгүй чанарыг ойлгож, зовлон эдлэх үзэл санааг номлодог байсан, гэтэл зовлон эдлэх үзэл санаа бол хүмүүст нөлөөлөх маш хүчирхэг хэрэгсэл, үүнийг сүм хийд тун ч чадамгай ашигладаг юм. Тэгсэн хэрнээ Достоевский даанч уйтгартай бичнэ, уран сайхан байхгүй муу бичнэ.

Оросын аугаа их зохиолч бол Пушкин! Бух юмыг ойлгоно, бүх юмыг гадарлана, бүх юмыг чадна. Зөвхөн Пётрын дүрийг ухаарсныг л бодоод үз л дээ! “Төмөр хазаарын хүчээр Оросыг орвонгоор нь босгосон”! Түүний уран бүтээлийн оргил нь “Борис Годунов”: “Манай мунхаг ард түмэн итгэх нь амархан; гайхам үзэгдэл, шинэхэн юмсыг харж бишрэх дуртай; дээд ноёд Годуновыг өөрсөдтэйгөө тэнцүүлэн дурсана... Хэрэв чи зальжин болоод хатуу гартай бол...” Яг хэлсэн юм шүү! “Мунхаг бөгөөд итгэх нь амархан” гэдэг бол ард түмний мөн чанар. “Зальжин бөгөөд хатуу гартай» гэдэг бол ТҮҮНИЙ засгийн мөн чанар. “өөрсөдтэйгөө тэнцүүлэн дурсана” гэдэг бол ТҮҮНИЙ эсрэг этгээдүүдийн мөн чанар. Борис Годуновыг бүр залуу байхаасаа биширсэн, Отрепьевын дүрийг биширсэн... “Сахилгүй гэлэн, оргодол бадарчин, нартын нас гэвэл дөнгөж хорь... Харин чацаар бол намхан, цээж өргөн, өрөөсөн

гар нь татуу, үс нь халиун шар”. Тэрээр шашны сургуульд байхдаа Пушкиныг уншсан байж магадгүй. Пушкин сургуулийн программд ордог байсан, гэхдээ “Борис Годуновыг” сургуулиас хөөгдсөнийхөө дараа одон орны судлалын газар товчоологч байхдаа хожим жинхэнэ ёсоор уншжээ. Мань хүн тухайн үедээ биеийн байцаалтдаа “Марксизмыг сурталчилсны учир Тифлисийн шашны дунд сургуулиас хөсөр хөөгдсөн” гэж бичсэн учраас марксизмыг сурталчилсны харгайгаар сургуулиас хөөгдсөн мэт одоо бичигчээдэг билээ. Уул нь сургуулиас өөр шалтгаанаар хөөгдсөн юм. Ээж нь Эгнатошвилээс авсан мөнгөө сар болгон түүнд гуйвуулдаг байсаар атал сургалтынхаа төлөөсийг төлөөгүй учраас хөөгджээ. Гэхдээ мань хүн санваартан болохыг зориогүй учир шашны дунд сургуулийг төгсгөх дургүй, тэр үед марксист дугуйлантай холбоотой болчихсон байжээ. Харин марксизмыг сурталчилсны учир хөөгдсөн гэдэг тайлбар бол зүйтэй тайлбар, яагаад гэвэл жолоодогчийн дүрийг бататгаж байгаа буюу тэгснээрээ хувьсгалын үйл хэрэгт үйлчилж байна.

Одон орны судлалын газар байхдаа л мань хүн “Борис Годуновыг” дахин уншжээ... “Сахилгүй гэлэн... Оргодол бадарчин... Нартын нас гэвэл дөнгөж хорь... Харин чацаар бол намхан, цээж өргөн, өрөөсөн гар нь татуу, үс нь халиун шар...” Мань эр ч гэсэн тэр үед хорин настай байсан, бас сургууль төгсөхөөсөө нэг жилийн өмнө санваартны зиндаа хөөхөөс татгалзсан. Мань хүн ч гэсэн чацаар намхан, цээж өргөн, бас үс нь хонгордуу, өрөөсөн гар нь хөдөлгөөн муутай. Тэрээр хэдийн хөвгүүн насыг давж хий мөрөөдөгч байхаа больсон, мэдээжээр Отрепьевыг өөртэйгөө зүйрлүүлж бодоогүй, ер нь ч тэр аз муутай нэгэн эр түүний шохоорхлыг татаж байгаагүй. Тэгсэн ч гэсэн гадна талын төс нь үнэхээр гайхмаар. Отрепьевын хэрэг бүтээгүйн шалтгааныг Пушкины ухаарсан нь бас үнэхээр гайхмаар: задгай амтай, хамаг нарийн нууцаа хормойд нь салхи дэвсэн нэг польш хүүхэнд илчилчихсэн, хүнлэг сайхан сэтгэлтэй, улс төрийн бодлоготон хэн хүнгүй өөрийн эрхгүй хэрэглэдэг элдэв аргын төлөө санаа зовж шанална. “Сайхан Москва орох хүслэнт замыг би дайснуудад зааж өгнө”. Болчимгүй сайхныг мөрөөдөгч болохоос улс төрийн бодлоготон биш! Дур зориг, нэр алдрын шунал, эрэлхэг зориг, аз эзийн туршил, ялах эрмэлзэл, түүнийгээ бататгаж чадахгүй, үр шимийг хүртэж чадахгүй арчаагүй байдал энэ тэр гээд бүх юм түүнд байжээ. Засгийн дээд эрхийг гартаа оруулаад тогтоож чадалгүй алдана гэдэг бол урагшгүй улс төрийн бодлоготнуудын хувь тавилан, засгийн эрхийг авахаас тогтоон барьж байх нь хэцүү л дээ. Отрепьев тогтоож чадаагүй. Тэрээр Москвад хаан ширээнд залагдсаныхаа дараа өөрийгөө хүү нь гэж зарласан тэр хаан эцгийнхээ хийсэн зүйлийн үгүйдээ аравны нэг хувийг хийсэн бол ийм явдал болохгүй байсан юм.

Гэвч энэ тухай мань хүн одоо л ингэж бодож байгаа болохоос тэр үедээ юу гэж бодож байснаа эс санана. Гагцхүү гадна талаасаа тэр хоёр их төстэй байсныг гойд гайхсан нь тодхон санагдана. Төрийн дээд эрхэнд өргөмжлөгдсөн оргодол бадарчны хувь заяаг үнэхээр гайхан биширсэн. Улирах цагийн эрхшээлд энэ дүр түүний бодол сэтгэлийг эзэмдсэн бусад түүхт хүмүүст шахагдан ой тойнд бүдгэрэн балархайтжээ. Тэглээ ч гэсэн тархины гүнд аль нэг эд эсэнд энэ дүр хоногшин үлджээ. Баку хотод польшийн үе улирсан сурвалжит эмэгтэй Софья Леонардовна Петровскаятай уулзахад нөгөө дүр санаандгүй тодрон гарч ирсэн биш биз? Пролетарийн нууц байгууллагын хувьсгалч гишүүн, салмайсан өмдтэй, сахлаа хусаагүй догшин зожиг царайтай, шургуу зоригтой, хүч тэнхээтэй тэрбээр сайхь хүүхэнд сайхан санагддаг байжээ. Нэг удаа ирэхэд нь хүүхэн эзгүй байж таараад дараачийн удаа ирэхэд нь инээд алдан,

–Манай хөршийн охин надад “Софья Леонардовна, танайд нэг аймшигтай ах ирсэн” гэж хэлсэн шүү гэжээ.

Манай хүн тэгэхэд жуумалзасхийн хямсайсан боловч хүмүүсийг айлгаж байхыг хүсдэг тул тэгж тодорхойлсонд сэтгэл өег байжээ.

Өрөвч зөөлөн сэтгэлтэй Софья түүнийг халамжлан санаа тавих агаад энэ бол чухамдаа мань эрийн хувьд насандаа эдэлсэн хамгийн дэврүүн хайр сэтгэл болой. Тэр хүүхэн эсерийн талыг баримталдаг хэдий боловч намын зүтгэлтнүүдийн эвлэршгүй зан байхгүй учир түүнтэй хэзээ ч үл маргахын гадна үзэл бодлоо тулгах гэж ер оролдохгүй, харин ч болбоос хүн зөрөх тоолонд цаадах нь уцаарлан унтууцдагийг мэдэх учир улс төрийн маргаанаас зайлсхийдэг бүлгээ. Гэхдээ хүүхэн түүнийг уцаарлуулж байгаагүй, түүнд уцаар төрүүлдэггүй цорын ганц хүүхэн тэр билээ. Гэвч тэдний харилцаа тас үсэрчээ... Софья уушигны сүрьеэгээр нас барсан аж.

Мэдээжийн хэрэг мань хүн Отрепьев биш, Софья нь Марина Мнишек биш. Тэглээ ч гэсэн польшийн сурвалжит хүүхэн, цагтаа санваартан болж чадаагүй, тодорхой бус ч томоохон зорилго өвөрлөсөн нууц хувьсгалч хоёрын тухай одоо бодохдоо энэ явдлын анх үүдэх болсон шалтгаан нь тархины тэртээ мухарт зүүрмэглэн байсан чухамхүү тэдгээр дүрнээс улбаалан гарч ирсэн байж болох юм гэж санадаг авай.

Харгис бүлгийнхний гарт амь эрсэдсэн нефтийн үйлдвэрийн ажилчин Ханлар Сафаралиевыг есдүгээр сард Шиховын оршуулгын газар хөдөөлүүлжээ. Үй олон хүн жагсаж, үйлдвэрийн яндан хангинан, жагсаал дотор ТҮҮНЭЭС гадна Шаумян, Енукизе, Азизбеков, Оржоникизе, Жапаризе, Фиолетов энэ тэр явжээ. ТЭРЭЭР үг хэлж, тэгэхэд Софья ч тэнд бас байсан ажээ. Гэтэл хагас жилийн дараа энэ оршуулгын газар түүнийг бас оршуулжээ. Жагсаал ч байхгүй, яндангийн дуу ч байхгүй. Австай цогцосны араас хөрш айлын авгайчуул, танил хэдэн польш л дагажээ. Нүх рүү хийж шороогоор булчихаад буцацгаасан. Харин мань хүн танихгүй хүмүүстэй хамт буцмааргүй санагдсан учир тэндээ үлдсэн. Тэдэнтэй ярих юм ч байсангүй. Хоцроод шинэхэн овгор шорооны хажууханд явган суужээ.

Хадан хясаатай Шихово хошуу тэнгис рүү зүтгэх мэт түрж ороод нефтийн тоо томшгүй олон цамхаг босгосон Биби - Эйбатын дээгүүр сүндэрлэнэ. Цамхгуудын түүгээр ажилчид эс харагдавч дохиур нь дээш доош тонголзон нефтиэ шахсаар байна. Хаврын урь дөнгөж орж байгаа боловч нарны элч хэдийн мэдэгдэн сайхан ээх ажээ. ТЭРЭЭР Каспийн тэнгисийн эрэгт хадан хясаатай Шихово хошууны хяр дээр суугаад тохойн ус руу, нефтийн тоо томшгүй олон цамхгийг харж байна. Үнэлж явсан цорын ганцхан Соня хүүхнээ оршуулсан хэдий ч толгой өөд татахын аргагүй уй гашууд автсангүй. ТЭРЭЭР Батуми, Кутаисийн шоронд сууж, Дорнод Сибирыг цөлөгдөж шорон, цөллөг, цөллөгөөс оргох энэ тэрийг нэгэнт биеэр амссаны дараа Өвөр Кавказын социалдемократуудын анхны байгууллага “Месами-Да-си”-д цуг байсан журмын нөхөд нь хэдийн халин одсон, Кецховели шоронд амь эрсдэж, Цулукизе нас барсан билээ. Цөмөөрөө халин одох юм, хойшид ч цөмөөрөө халин одно, хүний амьдрал гэдэг бол энэ эргэх хорвоод өчүүхэн хором төдий ажээ. Гагцхүү ӨНӨӨДӨР гэгч л байна. Энэ бол бас өчүүхэн хором, гэхдээ хувьсгалчийн хувьд бол жинхэнэ амьдралын хором. Гагцхүү хувьсгалч, гагцхүү эзэрхэн захирагч л хүний амьдрал арчаагүй өчүүхэн зүйл гэдгийг ойлгох агаад гагцхүү эзэрхэн захирагч л өөрийгөө хайрлан хамгаалах эрхтэй. Засгийн эрхийн төлөө

ТЭМЦЭЖ байх хооронд хувийн амь нас бол юу ч биш, харин засгийг эзэмдэн авсны дараа бол амь нас гэдэг чинь ялагчид ноогдох шан. Одоо ӨӨРӨӨ ялан дийлэгч, тэгэхлээр амь насаа хамгаалж чадна. Яагаад гэвэл засгаа хамгаалж чадах юм.

Аливаа хувьсгалч хүн амь насаараа аз туршдаг билээ. Мань хүн ч гэсэн бас л туршиж явсан, гэхдээ хянуур болгоомжтой явжээ. Бакуд ирэхдээ Балажарын тэнд буучихаад тэнгисийн хөвөөгөөр нефтийн цамхаг даган явган явж хот руу орно. Тэгээд ядрахын цагт зөрөг дээр амсхийж яг одооных шиг нүүрээ наранд ээн доошоо зам, цамхаг, тэнгис рүү харж суудаг байжээ.

Хувьсгалчийг юу жолоодож, бартаат замаар юу түүнийг хөтөлж явдаг вэ? Үзэл санаа юу? Үзэл санаа олон хүнийг эзэмдэн авдаг, гэтэл тэд цөмөөрөө хувьсгалчид болдог сон билүү? Хүнийг хайрлах сэтгэл үү? Хүнийг хайрлах сэтгэл бол халирхай хүмүүс, баптистууд, толстойчуудын хувь. Үгүй ээ! Үзэл санаа бол хувьсгалчийн хувьд шалтаг төдий зүйл. Бүх нийтийн аз жаргал, тэгш эрх, ах дүүсэг ёс, шинэ нийгэм, социализм, коммунизм энэ тэр бол олон түмний тэмцэлд дууддаг лоозонгууд. Хувьсгалч гэдэг бол араншин, тэр бол доромжлолыг сөрсөн эсэргүүцэл, хүн гэдгээ батлах нотолгоо. Түүнийг таван удаа баривчилж цөлж байсан, мань хүн цөллөгөөс оргож нуугдаж байсан, нойр хоолоор дутаж явсан, юуны төлөө ингэж яваа вэ? Өтөг бууцнаасаа өөр юу ч мэдэхийг хүсэхгүй байгаа тариачдын төлөө тэр үү? Ажилд зүтгэхээс өөр юмгүй энэ “пролетарийн” төлөө юу? Тэрээр Бакуд Баиловт байдаг Ротшильдийн ажилчны хуаранд байн байн хонож “ажилчин анги” гэдгийг үзэхээрээ нэг болсон билээ. Бакуд тэр удаа байх үед хэдийн намын нэртэй удирдагч болчихсон, Бакугийн большевизмийн толгойлогч байсан юм. Үүнийг үгүйсгэх гэсэн аливаа оролдлого бол бүтэлгүй оролдлого. Ийм оролдлогыг тас цохихдоо л нэг цохино. Сталин, олбогт сандлаасаа бослоо. Толгой дээхнүүр нь нэг зөгий нисэн бүр чихэнд чийртэй дүнгэнэнэ. Сталин түүнийг үргээсэнд нөгөө зөгий жаахан зайлснаа ширээн дээр суугаад үнсний сав руу дөхөхүйд мань хүн Ключевскийн ботиор няц цохив.

Тэрээр буцаж суух зуур нөгөө тэр үеийн бодол руугаа эргэж Авель Енукизегийн өөдгүй товхимлын тухай бодохдоо,

–Жигшүүртэй явдал, жигшүүртэй явдал! гэж гүржээр өгүүлэв.

Енукизе энэ товхимолдоо яагаад ч тэгсэн юм “Нина” гэдэг нууц нэртэй байсан Бакугийн нууц хэвлэх үйлдвэрийн тухай гэнэт бичихээр шийдсэн ажээ.

Энэ хэвлэх үйлдвэр Ленинд захирагддаг, захидал харилцааг Крупскаягаар дамжуулдаг, үйлдвэрийн ажлыг Красин, Енукизе, Кецховели гурав удирддаг байжээ. Авелийн бичсэнээр бол тэр хэвлэх үйлдвэрийн тухай тэд нараас өөр нэг ч хүн мэдэхгүй байсан гэнэ. Тэгэхлээр МАНЬ ХҮН, Сталин бас мэдэхгүй байсан байх нь. Сталинд ӨӨРТ нь тэр тухай ярьж ч байгаагүй байх нь.

Ротшильдийнхэн, бас Манташевийнхэнд алба хааж байсан нөгөө цахилгааны инженер Красиныг бол ойлгож болохоор байна. Ленин нууц байдлыг дээд зэргээр сахиж байхыг түүнд тушаасан юм чинь, ТЭРЭЭР түүнд гомдох юм байхгүй. Красин аль хэзээний нас барсан. Бас Кецховели ч нас барсан. Түүнээс гадна энэ муу жижигхэн хэвлэх үйлдвэр ч хувьсгалын хувь

заяаг шийдсэн юм биш. Тэр үед байдал тийм байсан.

Одоо бол байдал өөр байна. ТҮҮНД Баку, Тифлис, өвөр Кавказын титэм хэрэггүй байгаа юм. ТҮҮНД намын жинхэнэ түүх хэрэгтэй, жинхэнэ түүх гэдэг бол гагцхүү намын удирдлагын нэр хүнд, ашиг сонирхолд нийцэж байгаа түүх юм.

Хэрэв МАНЬ ХҮН Бакуд хажууханд нь нууц хэвлэх үйлдвэр байсныг мэдээгүй юм бол Орост намын жолоог өөрөө барьж байсан гэж одоо зүтгэж яаж болох билээ? Хэрэв өөрөө намыг удирдаж байсан юм бол тэрээр хэвлэх үйлдвэр байсан тухай мэдэхгүй байх ёсгүй гэсэн үг. Үүнийг үгүйсгэнэ гэдэг бол түүний ролийг Лениний баруун гарын туслахынх нь хувьд үгүйсгэнэ гэсэн үг. Нөхөр Авель Енукизе үүнийг үнэхээр ойлгохгүй байна гэж үү дээ? Ойлгохгүй байх ёсгүй. Тэгвэл нөхөр Сталин “Нина” гэдэг хэвлэх үйлдвэрт ямар ч холбогдолгүйг тодорхой харуулсан товхимол яах гэж гаргав? Ингэх хэрэг нөхөр Енукизед яагаад гарав? Яагаад гэнэтхэн түүх рүү орох болов? Гэтэл ийм хүнд Кремлийг, өөрийнхөө амь насыг итгэн даатгачихсан байх юм! Кремлийн комендантын газарт тийм намын олон ахмад гишүүний хэрэг юу байна? Хамгаалалтыг ийм зарчмаар сонгож авдаг гэж үү? Хамгаалагч хүнд хамгаалалтынх нь ажил улс төрийн зорилт юм бол улс төрийн үзэл бодол өөрчлөгдөж болох учраас тийм хамгаалагч найдваргүй юм. Тэр ч атугай хувийн сайн харилцаа ч найдваргүй, яагаад гэвэл сайдахаас муудахад хүрэхэд ганцхан алхмын зай бий. Хамгаалагч бол эзэндээ гарз нохой мэт үнэнч байх ёстой, жинхэнэ хамгаалагч гэдэг бол тэр. Ганцхан юм л мэдэж байх ёстой. Өчүүхэн төдий гэнэ алдаж маш яльгүй ч гэсэн дутагдал гаргаваас хамгаалагч хамаг буян, эрх ямбаа амь насныхаа хамт алдана. Өөрийнх нь хамгаалалтыг ийм байдлаар л сонгож авах ёстой. Гэтэл нөхөр Енукизе Кремлийн комендантаар Петерсоныг, хуучин Троцкийн галт тэрэгний дарга байсан, Троцкийн талын хүнийг байлгасаар байна. Ордны эргэлт хийхээр сэдэж байх нь уу? Енукизе тэдэнтэй нэгсэж байгаа юм байна. Энэ нь тэр муу арчаагүй товхимлоос нь харагдаж байна, тэр товхимлоороо өөрийгөө илчлэх чинь энэ дээ!

Энэ өдөөн хатгасан өөдгүй товхимлыг үнсэн товрог болгох хэрэгтэй. Авель түүнээсээ няцаж уйлж унжиж, гэмшиж гарах нь мэдээж, гэхдээ гэмшиж байгаа хун бол улс төрийн хувьд нэгэнт төгссөн хүн юм. Үүний дараа тэр хүн бие мах бодиороо байна уу, үгүй юу гэдэг нь түүний төрөл төрөгсөд, ойр дотнынхноос бусад хүнд ёстой падгүй болно. Төрөл төрөгсөд, ойр дотнынхон нь тэсэх л дээ.

Энэ товхимлын тухай бичих даалгавар хэнд өгөх вэ? Бакугийн ахмадуудаас л нэг хүн байвал зүгээр дээ. Харин тэднээс хэн үлдсэн билээ?

Оржоникизе Бакуд очиж байсан хүн, Балаханы районд Шамси Асадулаевын нефтийн үйлдвэрт, захын нэг жижигхэн байшинд өвчтөн хүлээн авах газар бага эмчээр ажиллаж байсан. ТЭРЭЭР тэр жижигхэн байшинг сайн санаж буй. Хоёр өрөөтэй, нэгэнд нь Серго аж төрдөг, нөгөөд нь өвчтөнөө үздэг байсан. Бага эмчид үзүүлэх хүн алийг тэр гэх билээ, тэгэхлээр энэ байр нууц уулзалтад тун тохиромжтой аятайхан газар байж билээ. Серго тэнд нэг жил хэртэй ажилласан байх. Дараа нь Бакуг бишгүй дайрч явдаг байсан. Уул нь жинхэнэ сайн гэрч мөн боловч завгүй гээд хавьтуулахгүй, нэмэрт нь Авель Енукизегийн найз юм чинь нөхрийнхөө эсрэг яаж гэрчийн этгээд болох вэ дээ.

Вышинский? Дүүрчихсэн үл бүтэх этгээд. Нэг насаараа меньшевик явсан хүн, тэр ч ойлгомжтой, меньшевик байна гэдэг бол сайхан ярьчихаад л юу ч хийхгүй байж болно гэсэн үг юм чинь. 1908 онд Балаханы Ардын ордонд Бакугийн зубатовчууд[11] болох Шендриковынхныг шүүн таслах хурал зохион байгуулагдсан. Хэн тэднийг өмгөөлж байсан билээ? Вышинский. Ганцхан шөнийн дотор таван удаа үг хэлж уран цэцэн ярьж байгаадаа өөрөө бах нь ханаж байсан шүү, муу хоосон цэцэрхэгч залины хөрөнгө! Арван долоон оны зун Москвад Арбатын цагдаагийн газрын дарга байхдаа Ленинийг эрэн сурвалжилж баривчлах тухай тушаал энд тэнд нааж, заяагүй тэнэг толгой чинь тэр тушаалынхаа дор “А. Вышинский” гээд бүр гарын үсгээ тавьчихсан байсан. Октябрийн эргэлтийн дараагаар яаж ийж байгаад ӨӨРТЭЙ нь уулзаж гэмээ хүлээж, уйлж унжсан удаатай. Гэхдээ Баиловын шоронд нэг өрөөнд цуг хоригдож байхдаа эргэлтээр ирсэн юмнаасаа өөртэй нь хуваалцдаг байсан тухай нэг ч үг дурсаагүй. ХЭНТЭЙ ярьж байгаагаа ойлгож байсан хэрэг, бас энэ тухай дурсвал ТЭРЭЭР түүнийг өршөөхгүй, тэр л өчүүхэн эргэлтийн хишигнийхээ оронд амь насаа авч үлдэж байгааг ойлгож байсан хэрэг. ТЭРЭЭР түүнийг 1920 онд намд элсэхэд нь, 1925 онд Москвагийн их сургуулийн захирал болоход нь, 1931 онд ЗСБНХОУ-ын прокурор болоход нь түүнд тусалж байсан, одоо Вышинский ЗСБНХУ-ын Ерөнхий прокурорын орлогч боловч намын дотор түүнийг үзэн яддаг болохоор Бакугийн явдлын талаар гэрч болгох хүн даанч биш.

Тэгэхлээр Киров үлдэж байна. Тэрээр хувьсгалаас өмнө Бакуд очиж байгаагүй ч гэсэн хувьсгалын дараа таван жил Азербайжаны эзэн байхдаа бүхий л архивыг үзэх боломжийг ашиглан Бакугийн намын байгууллагын түүхийг сайн судалсан, мэдлэг чадвартай, юмыг нарийн үздэг хүн. Енукизегийн муу товхимолд хариу өгөх хүн яг мөн. Тэр л өөрийнхөө нэр хүндээр намд хэрэгцээ байхгүй тэр нэг үндэслэлийг няцааж, оронд нь намын удирдлагын нэр хүндийг бэхжүүлэх үндэслэлийг дэмжиж байвал таарахсан. Уул нь аман дээрээ нөхөр Сталиныг өргөмжилж л байгаа л даа, гэхдээ үг бол чамлам зүйл. Тэрээр чухам энэ учраас Кировыг дэргэдээ нэг хэсэг ажиллаг, одоо ямар болсноо үзүүлэг хэмээн Сочи руу дуудсан ажээ. Тэр гурав нийлэхэд сайхан бүлэг гарна. Жишээ нь гурвуулаа хөгжимд дуртай, ӨӨРӨӨ зүгээр л дуртай, Жданов бол бүр төгөлдөр хуур дарна. Киров бол бараг хөгжмийн донтой, дуурийн жүжиг үздэг хүн, тэгэхдээ Засгийн газрын лоожинд биш танхимын голын суудалд сууна, уг ухаан нь бас ардач хүн байх нь! Хэзээнээсээ нааш сэхээтэнтэй адилсах дуртай, хэдийгээр дөнгөж Аж үйлдвэрийн дунд сургуульд суралцаж байсан ч гэсэн залуудаа оюутны сайн дурын жүжгийн тоглолтод оролцож байсан гэж байгаа. Түүний залуугийн зургийг нэг газар үзсэн, Сергогийн билүү, эсвэл Кировын өөрийнд нь билүү. Өө тийм, авгай нь Маркус, нэр нь хэн сэн билээ дээ, Марья Львовна гэдэг байх. Олон товчтой хүрэмтэй, алх түлхүүр хоёр зөрүүлсэн дүрстэй Аж үйлдвэрийн дунд сургуулийн төмөр тэмдэг бүхий дүрэмт малгайтай зураг үзүүлж байсан юм байна. Тэр хувцас нь мэдэхгүй хүнд бол гимназийнх шиг тэр ч байтугай оюутных шиг харагдана.

Гэтэл тэр нөхөр ирэх дургүй байгаа юм даа! Бие өвчтэй, эмч нар эрдэст ус уухыг зөвлөсөн гэж шалтаг заасан. Чи яасан юм бэ? Цээж хорсдог... Цээж хорсдоггүй хэн байсан юм бэ, түүнийг ямар өвчин гэх вэ дээ. Чи хүрээд ир, бид чамайг эмчилчихнэ, хэсэг цуг ажиллая л даа. “Би түүхийг яаж ойлгох вэ дээ...” - “Бид нар ч гэсэн юу ойлгож байгаа юм бэ? Гэсэн ч ингээд ажиллаж байна, чи ч гэсэн бидэнтэй ажилла л даа”.

Нүдэнд ил хамт нэг хэсэг байг, нарийн яривал тэр хоёр ер нь цуг байж үзээгүй юм байна. Хувьсгалаас өмнө ерөөсөө тааралдаж байгаагүй, иргэний дайны үед хоёр, гурван удаа бие бие харсан. Киров Азербайжаны намын байгууллагыг толгойлж намын их хурал, Төв Хорооны бүгд хурал, бусад ажил явдлаар Москвад ирж очих болсноор тэдний хооронд илүү ойр харилцаа үүсжээ. Ер нь аятайхан сэтгэгдэл төрүүлж байсны гадна Оржоникизе түүнийг магтдаг, хилийн чанадад байж үзээгүй, цагаачидтай огт хамаагүй, намын мэргэжлийн боловсон хүчин, Троцкий, Зиновьев, Каменев, Бухарин энэ тэрийг эвлэршгүй эсэргүүцдэг хүн. Уул нь Бухаринтай нөхөрсөг харилцаатай хэрнээ тэр. ӨӨРӨӨ л түүнийг дэвшүүлж яваа. Аравдугаар их хурлаар Төв Хорооны орлогч гишүүн, Арван хоёроор - Төв Хорооны гишүүн болгож, гучин онд Улс төрийн Товчоонд оруулсан. Түүнийг ӨӨРӨӨ Ленинград явуулж, энэ хэзээ мөнхөд эсрэг үзэлтэн, үл тоомсорлон зөрөх бардам зантны өлгийг бут ниргэх ажлыг итгэж даалгасан. Гэвч найдварыг биелүүлээгүй. Хотыг бут ниргэхийн оронд түүнийг толгойлж, амар хялбараар нэр төр олж аваад одоо бүх холбоотын хэмжээнд нэрд гарахыг эрмэлзэн, нөхөр Сталинтай жиших юм бол номхон дөлгөөн, уудам сэтгэлтний дүр гаргах санаатай байгаа юм. Улс төрийн Товчоон дээр Рютиныг цаазлахын эсрэг санал тавьж дараа нь Смирнов, Толмачёв, Эйсмонт гурвыг цаазаар авахыг эсэргүүцэж байсан. Тэгээд Улс төрийн Товчооны бусад гишүүдийг уруу татсан. Молотов, Ворошилов хоёр хүртэл эргэлзэхэд хүрсэн. Ганцхан Лазарь Каганович л үг дуугүй буудан алах саналтай байсан.

Ялагдагсдад уудам сэтгэл гаргах явдал аюултай. Дайсан чиний уудам сэтгэл гаргасныг хэзээ ч үнэмшихгүй, улс төрийн холбирол гэж үзээд боломж гармагц өөрөө дайрна. Гагцхүү гэнэн хүн л үүнээс өөрөөр бодох байх. Киров бол аюултай идеалист хүн, ажилчин ангийн материаллаг аж байдлыг сайжруулахыг шаардаж байгаа, материаллаг талаасаа бүрэн хангагдсан хүн хохирол хүлээх, бадрангуй сэтгэлээр зүтгэх чадваргүй болж, амиа борлуулах бэртэгчин үзэлтнүүд болж хувирдгийг ойлгохгүй байгаа хэрэг. Гагцхүү зовлон зүдгүүр л ард түмний аугаа их эрч хүчийг оргилуулдаг, тэр эрч хүчийг нураан сүйтгэх хэрэгт ч чиглүүлж болно, бүтээн байгуулах үйлсэд ч чиглүүлж болно. Хүний зовлон бол бурхан руу хөтөлнө. Христосын шашны энэ гол номлолоор ард түмэн олон зуун жилийн турш хүмүүжиж, мах цусанд нь нэгэнт шингэсэн болохоор үүнийг бид ч гэсэн ашиглах ёстой. Социализм бол хурмастад байдаг үлгэр домгийн диваажинг бодвол илүү шохоорхол татах энэ орчлонгийн диваажин. Үүнд хүрэхийн тулд мөн адилхан зовлон туулах ёстой нь үнэн. Гэхдээ ард түмэн эдэлж байгаа зовлонгоо түр зуурынх гээд аугаа их зорилгод хүрэхийн тулд ингэх шаардлагатай, дээд засаг төр нь тэднийхээ гачигдлыг мэдэж санаа тавьж байгаа, тэднийг ямар ч шатны албан тушаалын хүнд сурталтнуудаас хамгаалж байгаа гэдэгт бат итгэсэн байх ёстой. Дээд засаг төр бол МЭДДЭГ, ХҮРДЭГ, ЧАДДАГ газар.

Тэрээр өчигдөр үүнтэй холбогдуулан юун тухай бодож байлаа? Хүн амын хангамжийн тухай юу? Хүнсний бүтээгдэхүүний тасалбарыг халах тухай юу? Гэтэл энэ чинь шийдчихсэн асуудал, нэгдүгээр сарын нэгнээс тасалбарыг халж байгаа. Ингэхлээр ер нь юун тухай бодсон байна аа? Өө тийм! Тэрээр эстон цэцэрлэгч Арво Ивановичтай ярьсан зүйлийг өчигдөр бодсон шүү дээ. Арво Иванович орос авгайтай, энэ нутгийн хүн бөгөөд өөрт нь илтгэснээр бол гарцаагүй найдвартай, шалгагдсан, насаараа Сочид аж төрж байгаа, гаргуу сайн цэцэрлэгч гэж алдаршсаны учир түүнийг Ворошиловын нэрэмжит сувиллын амралтаас Засгийн газрын зусланд шилжүүлж авсан ажээ. Энэ зууны эхээр Балти орчмоос хэдэн зуун эстон Сухумийн тойрогт нүүн ирж, Хар тэнгисийн эргээр гурав билүү дөрвөн эстончуудын тосгон

бий болж, тэр эстончууд нутгийн ардын нэгэн адил жимс тарих, мал аж ахуй үржүүлэх (гэхдээ тэдний мал нутгийнхаас биеэр товируун) зэрэг ажил эрхлэн байсныг Сталин хэдийгээр мэдэх боловч Кавказад байхдаа эстон хүнтэй тааралдаж явсангүй. Гэхдээ эстончууд Сочид бас суурьшсан гэдгийг тэрээр мэдэхгүй явжээ. Арво Ивановичийг гаднаас нь харахад тавь эргэм настай, шанаархуу, цайвар халиун үстэй, тунгалаг нүдтэй бахимхан эр. Тэрээр аливаа эстон хүн шиг дотуур хантааз, хүрэмтэй явах боловч хүлхгэр өмднийхөө түрийг кавказынхан шиг савхин гуталдаа чихэж өмсөнө. Оросоор ярихдаа зарим үгийг инээдэмтэй урвуулж нэлээд аялгатай ярина. Түүнийг өчигдөр цэцгийн бутсыг танаж байхад Сталин өөрөө цэцгэнд дуртай болохоор яаж ажиллахыг нь харж байжээ. Арво Иванович урамгүй бололтой амандаа нэг юм үглэж байхыг үзээд Сталин яагаад сэтгэл дундуур байгааг асуужээ. Арво Иванович авгай нь дэлгүүрээс юм авахад цаадуул нь жингээр дутаасан төдийгүй нэмэрт нь мөнгийг нь илүү авч залилсан байна гэж хариулжээ. Сталин орой нь хамгаалалтын даргад “Арво Ивановичийн авгайг дэлгүүрийнхэн жин дарж, мөнгө илүү авч залилсан байна. Буруутай хүмүүсийг хатуу цээрлүүл гэж хотын намын хорооны даргад мэдэгдээрэй” гэж хэлжээ.

Орос худалдаачин хэзээнээс нааш луйварчин байсан, өнөөгийн дэлгүүрийн худалдагч мөн луйварчин чигээрээ үлджээ. Наймдугаар сарын 7-ны хуулиас хойш улсын хөрөнгөнөөс хулгайлахаа айгаад хүн амаас хулгайлдаг болсон байна. Ард түмэн үүнийг харсаар байгаа хэрнээ яаж ч чадахгүй байна. Тэгэхлээр ард түмний өмнөөс ӨӨРӨӨ үүнийг хийх ёстой. ТЭРЭЭР дэлгүүрээр ордоггүй ч гэсэн ӨӨРИЙНХӨӨ ард түмний гачигдал зовлон, гомдол саналыг сайн мэднэ. Сталин босож сэрүүвчээс дотогшоо орлоо. Тэр өрөөнд нарийн бичгийн даргын том ширээний ард Товстуха сууж байв. Түүнийг ӨӨРӨӨ Сочид авчиржээ. Энд түүхч эрдэмтэд ажиллаж байгаа, тэдэнд МЭЛИ[12]-ийн орлогч захирал энэ сэхээтэн Товстуха хэрэгтэй. Тэрээр түүхийг мэдэхийн хамт намд одоо ямар түүх хэрэгтэй байгааг ойлгож байгаа хүн. Товстуха түүний нарийн бичгийн даргаар олон жил ажилласан учраас цаг үеийн асуудлын тухайд гэвэл бас сайн мэдэж байгаа. Энэ бүхний нэмэрт бас сүрьеэтэй хүн, жаахан нар үзэг л дээ. Харахгүй юу, ийм туранхай бөгтөр амьтан, ханиалгаад л, доогуур хараад л, ээ зайлуул, эмч нар түүнийг удахгүй гэж илтгэсэн шүү. Хайран хүн, үнэнч хүн юмсан!

–Барааны жин, хэмжээгээр худалдан авагчдыг хохироох явдалтай хийх тэмцлийн тухай Төв Хорооны шийдвэрийн төсөл бэлтгээрэй гэж Сталин өгүүлснээ, -Үгүй ээ... хэрэглэгчдийг... Бас илүү үнэ авах явдалтай... Ер нь ингэсэн нь дээр байх: жижиглэн худалдааны үнийг зөрчиж байгаа тухай гээ. Хэрэг явдлыг баримтаар түүж авах хэрэгтэй, энэ нь эд хэрэглэгч өргөн олны талаар намаас тавьж байгаа анхаарал халамжид харшилж байгааг заах хэрэгтэй. Гарсан хэрэг явдлын талаар Худалдааны ардын комиссар Микоян, Хоршоодын төв холбооны дарга Зеленский, БХҮЭТЗ-ийн дарга Шверник (үйлдвэрчний эвлэл ч гэсэн хөдөлмөрчдийг мэхлүүлж гомдоолгохгүй байхыг анхаарч байх ёстой) нарт зэмлэл хүлээлгэх хэрэгтэй. Тогтоол хатуу байх шаардлагатай. Жин хэмжээгээр мэхлэх, илүү үнэ авах энэ тэрд арван жилийн ял оноож байх тухай Төвийн Гүйцэтгэх Хороо зарлиг гаргаг! гэв.

–Баримт цуглуулахад хэсэг хугацаа хэрэгтэй.

–Тэгвэл зүгээр Төв Хороонд мэдэгдлээ... гээд биччих. Үгүй ээ! Төв Хороонд баримтууд байна. Яг тэгж бичээрэй.

Сталин сэрүүвчиндээ эргэж ирэн нүүрээ нар өөд харуулан сандалдаа дахин тухлан суугаад дахиад л Кировын тухай бодлогошров. Түүнийг үе залгамжлагч гэж нэрлэдэг. Гэтэл ӨӨРӨӨ Кировоос дөнгөж долоохон ах шүү дээ, тэгэхлээр юун үе залгамжлах тухай яриа байх билээ? Хэн нь түрүүлж нас барах нь бүү мэд, кавказынхан урт насалдаг. Ингээд бодоход нас барсны дараа залгамжлах бус нас барахаас өмнө залгамжлах тухай яригдаж байх нь. Тэгнэ вий гайгүй. Робеспьерийг балтаар цаазлах ял оноосон дээд хурал өөрт нь хэрэггүй. Робеспьер дээд хурлыг хэвээр үлдээснээр үйлтэй алдаа хийсэн юм. Наполеон дээд хурлыг тарааж хөөсөн, тэр нь ч зөв болсон, тийм учраас Наполеон бол аугаа их хүн. Харин Робеспьер бол хэдийгээр хэрцгий догшин байсан боловч чалчаа өмгөөлөгчийн төдийхөн хүн.

Кировыг нэг удаа Москвад ирэхэд Оржоникизегийнд цугларцгаасан билээ. Өөрөө, Серго, Киров, Ворошилов, Микоян энэ тэр байсан. Бас уригдаагүй ч гэсэн Каганович байсан. Серго түүнийг үл тэвчдэг юм. Гэвч МАНЬ ХҮН түүнд Лазарь, явцгаая, Серго оройн хоолонд урьж байна гэж хэлсэн юм. Киров тоо, физик, химид дуртай байсан, Аж үйлдвэрийн дунд сургуулийг шагналтай төгсөөд, инженер болох санаатай Томскийн технологийн дээд сургуулийн бэлтгэл ангид орсон гэж ярьж байсан, чухам юунаас болоод тэгж ярих болсон нь санаанд алга. Ингэхэд Иван Будягин тэр хоёр тэнд танилцсан юм биш биз дээ? Будягин бас тэр бэлтгэл ангид сурч байсан, бодвол энэ хоёрын үерхэл тэндээс эхэлсэн бололтой.

Киров бага ч гэсэн техникийн боловсролтой, техникт авьяас сонирхолтой хүн, тэгэхлээр аж үйлдвэрийг тэр л хариуцаг, яг сайхан таарна. Тэгээд аж үйлдвэрийг машиных, химийнх, барилга гэх мэтчлэнгээр салгаг л даа. Бүрэлдэж тогтсон аппаратууд, дуу хоолой нийлсэн бүлэг хүмүүсийг байнга задалж буталж, байнга хольж сүлж байх хэрэгтэй. Нөхөр Киров Улс төрийн Товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн даргын хувьд ийм аж үйлдвэрийг л удирдаж байг. Ингэхэд ичгүүртэй юм ер байхгүй. Улс орныг үйлдвэржүүлж байгаа үед эдийн засгийн гол салбар болсон аж үйлдвэрийг удирдахад ичгүүртэй юм байхгүй. Харин нөхөр Киров үүнийг зөвшөөрөхгүй бол, Москвад шилжин ирье гэхгүй бол тэрээр бусдаас хамаарахгүй бие даасан байдалтай үлдэж өөрийнхөө онцгой чиг шугамыг үргэлжлүүлэх бодолтой гэсэн үг болно.

Саша Бутырын шоронд байхдаа ч, цөллөгийн газар луу өртөөлөн хүргэгдэж явахдаа ч ингэж гуньж гутарч үзээгүй билээ. Бутырын шоронд сууж байхад шалгаж учрыг олоод суллана гэсэн найдлага, өртөөгөөр явж байхад суурьших газраа хүрч хугацаагаа дуусахыг тэвчээртэй хүлээнэ гэсэн зорилго байсан юм. Найдвар нь түүнийг хүн хэвээр нь байлгаж, зорилго нь амьдрахад тус болж байжээ. Энд бол найдвар, зорилго хоёрын аль нь ч алга. Сүүний машиныг ашиглахад хүнд тус болох гэсэн чинь хорлон сүйтгэх хэрэгт холбогдож буруутлаа. Алфёров маш нарийн учирлаж гарцаагүй нотолж өгсөн. Тэрээр Иван Парфёновичийн өргөдлийг гаргаж ирээд дуртай цагтаа өөрийг нь няц дарж чадахаар байна. Ингэж аж төрж болох уу? Москва руу захичихаад хүлээж байгаа франц хэлний сурах бичгүүд, бас улс төрийн эдийн засгийн ухаан, философийн номуудаар яах болж байна вэ? Номын санааг хэнд ярьж, францаар хэнтэй ярих хэрэг вэ? Тайгад баавгайтай ярих уу? Алфёров өөрийг нь хөндөхгүй байлаа ч гэсэн энд ямар орлогоор, яаж амь зуух болж байна вэ? Эсгий гутал л тахлахаас. Үүнийг сурч болно. Ийм хувь үлдэж дээ. Бүх юмыг мартъя, бүрмөсөн мартъя! Сэтгэлийн дуудлага болгон байж өсөж бойжсон үзэл санааг нь баулинчууд, лозгачёвчууд, дьяковчууд эзэмдэж аваад улан дороо гишгэн тэрслэн зөрчиж, тэр үзэл санаанд чин үнэнч хүмүүсийг нухчин дарж байна. Тэрээр энэ орчлонд чанга гартай, чин зоригтой байхгүй бол амархан мажийна гэж хуучин боддог байсан бол чухамхүү чанга гар, чин зоригоос болж цаашаа харах юм байна гэдгийг одоо ойлгожээ. Яагаад гэвэл чиний зориг түүнээс илүү хатан зоригтой мөргөлдөж, чиний гар төр барьж буй түүнээс ч илүү чанга гартай тулгардаг ажээ. Амь насаа авч үлдэхийн тулд бусдын эрх зориг, бусдын хүчинд захирагдаж, амиа хаацайлж, аялдан дагаж, бутны цаанаас бултайхаасаа айдаг туулай шиг хоног төөрүүлэх хэрэгтэй юм байна. Тэрээр гагцхүү ийм үнэ цэнээр хар толгойгоо хадгалж чадах нь. Ингэж аж төрөхийн хэрэг байна уу?

Саша ном унших гэж оролдон гэртээ сууж байлаа. Өвгөн хашаан дотор нэг юм засаж сүхээр тогшлох агаад энэ нэгэн хэмийн нэгэн янзын тогшоо улам гуниг төрүүлнэ. Өвгөн хашаанаас гараад явчихсан боловч Саша тэртэй тэргүй аль хэдийн уншиж чадахгүй байсан тул номоо орхилоо. Тэрээр ийм амьдралыг тэсэж давшгүй нь ээ. Дараа нь орон дээрээ хэвтэж дугхийсэн авч нойрон дундаа ч гай түүтгэрийн сэрлээс ангижирч чадахгүй айдсанд автан сэрвэл зүрх нь оволзон дэлсэж байв.

Алфёров өөрөөс нь юу хүсээд байна вэ? Өөриймсөг байгаа нь санаандгүй зүйл биш энд үлдээсэн нь ямар ч шалтгаангүй байж таарахгүй. Юм ёсоороо байдаг бол өөрт нь тэр хэргийг тулгаад л өөрийнхөө энд сууж байгаагийн идийг харуулмаар юм. Гэтэл мань хүн өөрийг нь Мозгова руу буцааж явуулсан төдийгүй Кежма руу МТС-д ажилд шилжүүлэх санаа цухуйлгасан хэрнээ хариуд нь юу ч шаардсангүй. Өөртөө татах гэж оролдож байна уу, эсвэл сэтгэл санаагаар унагах гээ юм болов уу? Туйлд нь хүртэл цөхрөөж, яахаа мэдэхгүй байнга айж цухалдсан байдалд барина даа чамайг, чиний тухай мэдүүлэг энд байж байгаа юм чинь чамд амар заяа үзүүлэхгүй, дахиад хэзээ дуудахыг хүлээж бай гэж байгаа вий. Гунигтай, яасан ч гунигтай юм бэ...

Авгай нөгөө өрөөнөөс,

–Юм идэх үү? гэж дуудав.

–Идэхгүй ээ, шүд өвдөөд байна гэж Саша хариулав.

Тэрээр хоёр өдөр гадагшаа гарсангүй, хашаан дотор өвгөнд энэ тэрхнээс нь элбэлцэж өнгөрөөв. Зида өөрийг нь хүлээж санаа зовж байгаа гэж мэдэж байвч түүнтэй уулзах хүсэл байсангүй. Түүний шившгээ дуудуулж байхыг хүүхэн харсан болохоор тайтгаруулах гэж оролдоно, тэгвээс улам доромжлуулсан хэрэг болно. Ер нь юу ч бай, хэн ч бай өөрт нь ямар ч ялгаа алга. Дуусгах хэрэгтэй! Энэ хүлээснээс гарах нь нэгэнт өнгөрчээ... Үгүй, тэгвэл ээж нь юу болох вэ? Ээж нь тийм юмыг тэсэж давж чадахгүй, ээждээ тийм муухай юм хийж яаж чадахсан билээ, тэгэхлээр энэ хударгандаа л зүтгэж байхаас өөр арга алга. Эсэн мэнд явааг нь ээж л мэдэж байгаасай, ээж л битгий горьдлого тасраасай.

Нөгөөдрийн маргааш нь Всеволод Сергеевич түүн дээр ирэв.

–Та яагаа вэ? Яагаад үзэгдэхгүй байна? Өвдөө юу?

–Бие зүгээр.

–Алфёров зовоож гүйцэв үү?

–Намайг хорлон сүйтгэгч бас хамтралын удирдагчийг гутаагч гэж нотолсон. Нарийн ухаанаар ямар ч эргэлзээгүй баталсан.

Всеволод Сергеевич инээд алдав.

–Та юуг нь гайхаа вэ? Тэр чинь философичийн мэргэжил эзэмшсэн хүн.

–Өө тийм үү?

–Тийм гээд бод л доо. Түүний албан тушаалд хууртахын хэрэггүй. Цаадах чинь том хүн, аюулаас хамгаалахын хоёр юм уу гурав дугаар зэргийн комиссар байх. Канскт байдаг дарга нараасаа дээгүүр цолтой гэж мэд, тэгээд л дүрэмт хувцсаа өмсөхгүй байгаа юм. Тэгж ярих юм бол гадаадад бас байсан хүн, тэгсэн хэрнээ энд ирчихсэн байгаа юм. Ирээдүйд бидний хань ч гэх үү, нөхөр ч гэх үү болох вий гэж би санаа зовж байна. Эсвэл дахиад дээшээ гараад ирж ч магадгүй, бүх юм та бидний үл мэдэх элдэв дээгүүр нөхцөл байдлаас л шалтгаална. Ямар ч байлаа гэсэн хамтралын даргын өргөдлийн дагуу таныг яйртал үйрүүлж чадна гэдгээ танд учир холбогдлыг нарийн гаргаж баталжээ. Сүүний машиныг эвдэлж, хамтралын даргыг мунхаг гэж доромжилсон. Тэр танд ийм хэрэг тулгав уу?

–Ийм хэрэг.

–За тэгнэ ээ тэр. Би таны сэтгэлийг амраая. Нөгөө сүүний чинь машиныг яг тэр өдрөө Кежмад аваачиж таны хэлсэн ёсоор бүх юмыг засаад буцааж авчирсан, одоо сайхан ажиллаж байгаа. Та гараад өөрөө харсан ч болно.

–Өчүүхэн төдий ч хүсэл алга.

–За Саша, тэр чинь яг зүйтэй. Дахиад тэр машинд бүү гар хүрээрэй гэж зөвлөө. Ингэхлээр хорлон сүйтгэхтэй холбогдсон асуудал арилж байна гэж бодож байна. Санаа бүү зов.

–Би санаа зовоогүй ээ. Зүгээр л бодохоос дургүй хүрээд байгаа юм.

–Аргагүй ээ. Харин та намайг илэн далангүй ярихаас дургүйцэхгүй бол би танд нэг юм хэлье. Тэгэх үү?

–Тэг л дээ.

–Саша, та бол аргагүй л хүн юм. Жинхэнэ хүн! Зөвлөлтийн хүн! Энэ бол гоё үг биш, үнэн үг. Үзэл санаандаа үнэнч, жинхэнэ зөвлөлтийн хүн байна гэдэг бол ёстой сайхан хэрэг. Гэтэл та одооныхоо ноцтой байдалд ч гэсэн тэр хэвээрээ байж, зөвлөлтийн хүн юманд яаж хандах ёстой шиг яг тэгж хандахыг хүсэж байна. Ингэж болохгүй шүү, Саша. Яагаад гэвэл та бол эндхийн хүмүүсийн хувьд зөвлөлтийн хүн биш, зөвлөлтийн эсрэг этгээд. Тэгэхлээр таныг ч гэсэн, таны үйлдлийг ч гэсэн чухамхүү ийм үзлийн үүднээс үнэлж цэгнэнэ. Та гудамжаар явж байгаад сүүний машин ажиллахгүй байгааг харж түүний бүтцийг мэддэг учраас очоод засаж байна. Гэтэл хамтралын дарга, бас бүрэн эрхт төлөөлөгч хоёр бол (би Алфёровыг хэлээгүй өөр ердийн төлөөлөгчийг хэлж байна) өөр юм бодож байгаа. Энэ чинь яагаад сүүний машин руу дайраад орчихов? Мэдээж шүү дээ, хэмхлэх гэж л тэр. Дайсан бол чадах бүхнээ хорлож сүйтгэнэ. Хэн ингэж хэлснийг мэднэ байх гэж найдаж байна.

–Мэднэ.

–Та нийгмээс шоовдорлогдсон хүн байхыг хүсэхгүй байна, гэхдээ өөрийнхөө байдлыг бодолцох ёстой. Хамтралын даргыг мунхаг гэж хэлсэн чинь таны гол алдаа. Хэрвээ та түүнийг цусаар урс гэхчлэн зүхлийн муугаар зүхсэн бол юу ч болохгүй байсан юм. Харин мунхаг гэдэг бол дайрч доромжилсон, харьцуулах утгатай үг, тэгэхлээр та ухаантай, тэр мунхаг гэсэн юм шиг болжээ. Алфёров таныг өөр тосгонд оч гэхгүй байна уу?

–Оч гэсэн.

–Тэгээд яасан бэ? Та дургүйцээ юу? Нурзида Газизовнагаас болж тэгээ юу?

–Би үгүй ч гээгүй, тэгье ч гээгүй. Та өөрөө шийд гэж түүнд хэлсэн. Би түүнд өртэй, хариу үүрэгтэй байхыг хүсэхгүй байна.

Всеволод Сергеевич бодолхийлснээ,

–За яахав, таны зөв ч байж магадгүй. Уул нь өөр тосгонд бол танд арай амар байх байсан байх. Энд бол та түрүүчийнхээ айлын хүүтэй муудалцсан, одоо ингээд даргатай ам муруйлаа, ер нь энд таны нэр базаахгүй боллоо шүү. Гэвч гайгүй байх гэж найдацгаая. Саша, одоо таны мэдрэл тэвчээр алдсан байна. Баривчилгаа, шорон, шилжүүлэг, өртөө, манай Мозгова, суух айл, элдэв хөөцөлдөх зүйл гэсээр таны мэдрэл пүрш шиг чангарсан байж л дээ. Тэгээд бүх юмны учир олдонуут нөгөө пүрш чинь ганцхан шинэ таталтаас болоод тас үсэрчихгүй юу. Бид бүгдээрээ ийм зам туулсан улс. Гол нь ингээд архагшичихгүй л байвал болох нь тэр. Та

бол зоригтой чийрэг залуу, энэ бүхнийг давах ёстой. Цорын ганц сургамж юу вэ гэхлээр тэдэнтэй зөрөлдөхийн хэрэггүй, бас багш хүүхэн та хоёр болгоомжтой байх ёстой. Танд хонзон санах хүн байгаа учраас одоо таныг мөрдөх болно, тэгээд ямар ч хэргийн хоморгонд хийчихэж мэднэ гэв.

Тэгснээ Сашагийн ор луу очиж мөрөн дээр нь алгадан,

–Боль! Босож үз! Явж хөзөр тоглоё гэв.

–Би хөзөрт муу.

–Тэр хамаагүй. Хөзөр бол бидний ганц зугаа, эрүүгийнхэн оноо[13], бид нар преферанс[14] тоглодог юм. Сахлаа хусчих, жигтэйхэн ургачихсан байна. Тэгээд хувцаслачих, явцгаая. Та эндхийн сэхээтнүүдтэй танилцах цаг болсон.

Саша явмааргүй байсан боловч Всеволод Сергеевич шалаад салдаггүй бас эндхийн бусад хүн яаж аж амьдралаа зохиож байдгийг үзэхэд ашигтай гэдгийг өөрөө ойлгож байжээ.

Михаил Михайлович Маслов гэдэг дөчин тав эргэм насны зүдэрсэн хэрнээ ярвагар царайтай эр ийшээ жилийн өмнө Соловки арлаас ирсэн ажээ. Байдал төрхийг ажвал офицер байсан гэж бодохоор.

Тэрээр Сашаг дагуулж ирсэн Всеволод Сергеевичид,

–Бид ч таныг ирэхээсээ өнгөрлөө гэж бодож байлаа шүү гэж цаанаа нэг хорон өгүүлэв.

–Биднийг мулз хожиж амжина даа гэж Всеволод Сергеевич цайлган зангаар өчив.

Тоглох үед Михаил Михайлович удаан бодуулахгүй яаруулж буруу гарвал зэмлэж байв. Харин гагцхүү Сашаг дайсны талын хүн гэж үзээд зэмлэж барихгүй, чухамдаа тийм цэрвүү харьцаагаар түүнийг гадуурхаж байлаа. Сашад ч гэсэн Михаил Михайлович зэвүүн санагдана. Тэрээр ийм хүн өөчилдөг уцаар хүнд дургүй, энэ бол хувь заяа биш зан араншин гэдгийг эцгийнхээ жишээгээр мэдэх билээ.

Дөрөв дэх тоглогч нь Пётр Кузьмич гэдэг Воронеж мужийн Старый Оскод хотод наймаачин байсан хүн аж. Ялын хугацаагаа Нарымаас эхэлж энд Ангарад дуусгаж байгаа юмсанж. Нас жар гаруй, мөр цээж ханхар, бие бахим, буурал суусан богинохон хууз сахалтай, өмднийхөө түрийг чихэж өмссөн савхин гуталтай, тохой нь гөлийсөн хуучин пиджактай. Тэрээр яаж хөглөж явснаа ярих дуртай эндхийн цорын ганц хүн болой.

–Зөвшөөрөхгүй байхад нь наймаа хийгээгүй, зөвшөөрсөн үед нь бол хийж л явлаа, тариачин хүнд хэрэгтэй хадуур, сэрээ, элдэв будаг цавуу гээд бага наснаасаа заалгасан зүйлийг зарна. Манай гацаанд хоршоо бий, гэвч тариачид над руу л ирнэ. Би тариачин хүнд хэзээ юу хэрэгтэйг андахгүй учраас надад юм болгон бэлэн байх л даа. Дараа нь мэдээж санхүүгийн байцаагч ар араасаа ирж албан татвар, гувчуур, хураамж гээд нэхнэ. Шоронд мөрдөгдөж байхад надаас алт нэхсэн, би алт хаанаасаа авах вэ дээ? Миний алт бол элдэв янзын хар

төмөр. Би тэр үед хааны аравт, тавтын алтан рублиэс өөр алт ерөөсөө үзээгүй.

Пётр Кузьмич мөрдөн байцаагчийг бас цаадуул нь шахаж байгаа л даа хэмээн гүндүүгүй өгүүлнэ.

—За яахав, би эрхээ хасуулсан худалдаачин хүн, гэтэл хүүхдэд ямар байх билээ? Тэд нар ямар өөрснөө эх эцгээ сонгож авах биш дээ? Хүний адилаар л аж төрөхийг хүсэж байгаа, тэгээд бусдын жишээгээр пионер, комсомолд элсэхийг бодно, гэтэл тэднийг бүх юмнаас хөөнө. Бага хүү Алёшка толгойтой эр юмсан, Москва руу явж үйлдвэрт ажилд орсон, тэгээд нэг сонин ирүүлдэг юм байна. Тэгсэн чинь “Би тэрний тэр, эцэгтэйгээ тангараг тасарсан, түүнтэй ямар ч холбоо байхгүй” гээд хэвлэчихжээ. Даанч гомдмоор. Хооллож, ундалж, өсгөж бойжуулсан нөгөө үр чинь тангараг таслахдаа хүрдэг байна. Ер нь ч яая гэх вэ дээ, өөр арга байсангүй. Түүнээс гадна наймаа хийх хортой гэдэгт мань хүн итгэж байсан, намайг бусдын хөдөлмөрөөр амьдарч байна гэдэг байсан юм чинь... Мухлаг дотор маажинтай торх эсвэл анжис, эсвэл хадаастай хайрцагтай ноцолдоод үзсэн бол ч манийхаа хөдөлмөр гээч юу болохыг таньж мэдэж л дээ... За тэр ч яахав! Алёшка хэзээний газарт дур сонирхолтой, тэгээд агрономич болохоор шийдэж дээд сургуульд орсон байна. Москвад нийтийн байранд суух боловч хүүхдэд нь идэх юм байхгүй, авгай нь шөнө ч унтаж чаддаггүй байж. Би гучин цаас явуулсан чинь буцаагаад ирүүлдэг байгаа даа, их үзэл сурталтай хүн шүү... Яая гэх вэ, сурталтай юм бол өлөн л сууж байхаас! Гэтэл ээж нь санаа зовж өр нь шимшрээд болох биш, нутгийн хүмүүсээр хэрчим гахайн өөх, гарын хэдэн боов явуулж өөрийг нь өгсөн гэж битгий хэлээрэй гэж захижээ. Нутгийнхан нийтийн байранд очтол Алёшка гэртээ эзгүй таарч тэд нар явуулсан юмыг шүүгээн дээр нь орхиж гэнэ. Дөрвүүлээ нэг өрөөнд суудаг, ор болгоны дэргэд нэг шүүгээтэй юм байж. Алёшка ирээд юм байхыг үзээд хэн авчирсан юм бэ? гэж дээ. Танай нутгийнхан авчирсан юм гэж. Үгүй ээ, эцэг эхээс ирүүлсэн байна, буцааж явуулна гэж Алёшка өчжээ. Гэтэл цаадуул нь буцаахын хэрэг юу байна, идэр залуу эрүүл чийрэг ч гэсэн өлөн улс байна, нударганчуудын өөхийг идэцгээчихье гэжээ. Тэгээд өөх боовыг аль альгүй цөлмөжээ. Гэтэл дараа нь нөгөө цөлмөсөн хэдийн нэг нь манай Алексейг эцэг эхээсээ юм авч байгаа, тэгэхлээр нөгөө холбоогоо тасалсан гээд байгаа нь худлаа болох нь гэх маягийн юм бичиж үүртээ өгчээ. Алёшка комсомол, дээд сургууль хоёроосоо хөөгдөж буцаад үйлдвэртээ ажилд орсон. Өөрснийхнөөсөө тангараг тасарсан чинь нөгөө бараадсан хүмүүс нь өөртэй нь тангараггүй болсон хэрэг...

—Наадхыг чинь зуудахиа сонсож байна хэмээн Михаил Михайлович түүний яриаг тасдаж, — Хөзрөө хараач гэв.

—Энэ залууд ярьж өгч болохгүй юу байх вэ, сонирхолтой байж магадгүй гэж Пётр Кузьмич зөрснөө, — Таны эцэг эх амьд уу? гэж асуув.

—Амьд гэж Саша хариулав.

—Тэд нар чинь өртөөгүй юү?

—Яасан гэж өртөх билээ?

—Хүсвэл ч өртөөх юм олно л доо. Хүү нь цөллөгт байгаа болохоор тэд нар чинь тэртэй

тэргүй амар заяа үзэхгүй байгаа. Тэгснээс өөрснөө Сибирыг зовж байсан нь дээр.

–Та хүүхдүүдээ буруу талаас нь өрөвдөж дээ хэмээн Михаил Михайлович буруушаан өгүүлээд, - Юм явуулж байж амьдралыг нь үрэн таран хийсэн байна. Таны тэр явуулсан юмгүйгээр үхэхгүй л байсан, бусад оюутан болгоод л байгаа шүү дээ. Ер нь тэдний биднээс тангараг тасарч байгаа нь зүйтэй, бид нар чинь өнгөрсөн улс. “Хувьсгал бол түүхийн бух тэрэг”. Тэр тэрэгний дор орсон хойно эвлэрэхээс өөр зам байхгүй! гэв.

–Хүү нь хүү биш, эцэг нь эцэг биш болох нь ээ.

–Яг тийм хэмээн Михаил Михайлович улам уцаарлаад, –“Эцэг эхийгээ хүндэлж яв” гэдэг чинь бурхны сургаал, гэтэл бурхан хэнд ч хэрэггүй. Цаадуулын чинь шашин бол эрх тэгш ёс. Ингээд хаа сайгүй ийм болно, дэлхийн хувьсгал хийчихээд бүхнийг тэгшитгэчихнэ гэв.

–Дэлхийн хувьсгал гэж та хэтрүүлж байна хэмээн

Всеволод Сергеевич ярианд оролцож, –Дэлхийн хувьсгалаас чинь большевикууд өөрснөө татгалзсан. Төр гэж орос хүний шашин шүтлэг байна, тэгээд л орос хүн төрийн эзэн хаанаа бурхан болгон хүндэлдэг юм. Бас үг дуугүй захирагдана. Тэгээд элдэв эрх чөлөө гэж ер хүсэхгүй байгаа. Эрх чөлөө гэдэг чинь бүх нийтээрээ бие биеэ алан хядахад хүргэнэ, харин ард түмэн бол дэг журмыг шаардаж байна. Надад бол Степан Разин, Емельян Пугачёв энэ тэрээс Ленин дээр, арга барахад Сталин ч дээр гэж өгүүлэв.

–Чухам тэр учраас л та бид энд байна.

–Харин тийм. Стёпка, Емелька энэ тэрийн үед бол улиасан дээр дүүжлээстэй байх л даа. Большевикууд Оросыг аварч их гүрнийг хэвээр үлдээлээ. Эрх чөлөө гэгч нь ирэх юм бол Орос хэсэг хэсэг болоод бутран унана. Шинэ эзэн хаан Оросыг бэхжүүлж байна, түүний заяа буян нь дэлгэрч явах болтугай. Хожмын тухайд бол бурхны аврал мэдэх хэрэг.

–Төр бол өөрийнхөө иргэдийг хамгаалж байх ёстой, гэтэл танай төр чинь тэдэнтэйгээ байлдаж байна. Надтай, тантай, Пётр Кузьмичтэй байлдаж байна, улс гүрний суурь болж байгаа тариачин эртэй байлдаж байна гэснээ Михаил Михайлович Сашагийн зүг дохиж, –Тэр ч байтугай өөрснийхөнтэйгөө хүртэл байлдаж байна. Би бол орос хүн, би бас Оросын төлөө байна, гэхдээ ийм Оросын төлөө биш гэж өгүүлэв.

–Өөр Орос бий болохгүй гээд Всеволод Сергеевич инээв.

Михаил Михайловичийнд очлоо гэж Сашагийн элдэв ёозгүй бодол сарнисангүй, нөгөө арга барагдсан цөхрөл хэвээр үлдлээ.

Тэрээр ийм шударга ч гэх үү, эсэргүү ч гэх үү яриаг мэддэг учраас ер сонирхдоггүй билээ. Харин ганц Пётр Кузьмичийн яриа л хүнлэг яриа, ЭЗШБ-ыг журам дэглэм эвдэхгүй устгаж даанч болоогүй юм байх даа... Ээжийнх нь явуулсан хэрчим өөхийг нөхөд нь ятгаж байгаад идүүлчихсэний учир нэг залуугийн амьдралыг үрэн таран хийх ч гэж дээ! Яасан ч харамсалтай юм бэ...

Тэрээр өдий хүртэл гэрээсээ нэг ч захиа аваагүй болохоор харамсал гуниг дээр нь ээжийнхээ төлөө санаа зовох түгшүүр нэмэгдэв.

Цөллөгийнхөн лхагва гараг бүрд Ангарын эрэг дээр цугларч шуудангийн завийг хүлээцгээнэ. Энэ бол тэдний нэгэн хэмийн амьдралын гол үйл явдал юм. Авгайчуул цагаан хэрэглэлээ усанд булхаж усанд орсон хүүхдүүд даарсандаа чичрэн гарч ирцгээж, цөллөгийнхөн манант голыг дагуулан алсын бараа ширтэж эрэг дээгүүр холхицгооно. Тэгж байтал тэртээ доор бүртийсэн хар юм үзэгдэхүйд шуудан мөн болов уу, биш болов уу хэмээн улам догдолцгооно. Юүдэнгээ ар шил рүүгээ буулгасан бэржээнтэн цувтай шуудан зөөгч “Мозгова” гэсэн модон пайзтай богцыг эрэг рүү гарган хаяж шуудангаа тарааж өгөөд явуулах захидлыг хүлээн авна.

Саша бас эрэг рүү очиж бусдын адил шуудан хүлээдэг боловч ганцхан Соловейчикээс “Цөллөгийн Наполеонд” гэж хаягласан захидал ирнэ. Хөөрхий Соловейчик тоглоом тохуу хийсэн хэвээр. Дахиад л урам зориг бадран, өөрийгөө Фрида руу юм уу, Фридаг өөр лүүгээ шилжүүлэх тухай санал хүсэлтээ бичиж байгаа ажээ. Саша Москвагаас, ээжээсээ юу ч авалгүй өдий хүрчээ. Тэрээр ээждээ Канскаас таван сард цахилгаан явуулсан, яг тэгэхэд анхныхаа захидлыг бас илгээсэн. Харин захиа Канск хүртэл нэг долоо хоног явдаг гэж саная, гэтэл тэр захиаг Канскт ирэхэд Богучанын шуудан явчихсан байг л дээ, тэгвэл бас нэг долоо хоног тэндээ хэвтэнэ гэсэн үг. Богучаныд ирээд Кежма руу хаяг өөрчилж явуулахыг хүлээж бас нэг долоо хоног хэвтэг нийлээд гурван долоо хоног болно, гэтэл мань хүн энд ирээд сар гаруй болж байна. Всеволод Сергеевич түүнийг тайвшруулж,

–Анхны захиа дандаа ингэж уддаг юм. Та өөрийнхөөрөө тоолж байна, гэтэл шуудангийн газар өөрийнхөөрөө тоолно. Москвагаас захиа заримдаа гурван долоо хоног явж ирнэ, заримдаа гурван сар явна, яагаад тэгдгийг хэн ч мэдэхгүй. Андуураад буруу богцонд хийчихнэ, тэрэг эвдэрчихнэ, шууданг тосгоны захиргаан дээр аваачаад хаячихна, тал нь үрэгдчихнэ. Шуудан зөөгч богцтой шуудангаа Ангара руу унагачихвал бух насаараа хүлээгээд ч ирэхгүй. Түүнээс гадна манай эрхэм хүндэт нөхөр Алфёров уйдаж үхэж байгаа учраас таны захидлыг дураа ханатал уншиж, хэрвээ аль нэг захиа жишээлбэл уран хэллэгийнхээ шинжээр онцгой сайхан санагдах юм бол тэр захиаг бүтэн сар ч өөр дээрээ байлгана, үгүй бол бүр аваад үлдсэн ч чадна. Таны тооцоо бол яг нарийн онож чадахгүй. Канскаас явуулсан цахилгааныг чинь будлиулсан байж болно, анхны чинь захиа ямар нэг шалтгаанаар ээжид чинь очоогүй бол дөнгөж хоёр дахь захиа чинь очсон байгаа, тэгэхлээр хариуг нь дахиад сар, сар хагас хэртэй хүлээх хэрэгтэй. Найз минь, тэвчээд байна шүү хэмээн учирлана.

Всеволод Сергеевичийн зөв л дөө, тэглээ ч гэсэн өөрөө юу ч авахгүй байхад бусад нь захиа, сонин, илгээмж авч байхыг хараад Саша бухимдана. Тэрээр шуудан болгоноор ээждээ хоёр, гурван захидал явуулж сайхан төвхнөсөн, сайхан байртай болсон, бас хаа сайгүй сайхан хүмүүс байх юм, надад дутаж гуцаж байгаа юм алга, юу ч ирүүлэх хэрэггүй гэж бичнэ.

Тэрээр гунигт автан голын эргээс гэр лүүгээ буцаж тосгоны гудамжаар явж байхад хүмүүс огт юу ч болоогүй юм шиг түүнээс өөр хүнийг л хорлон сүйтгэх хэргээр буруутгаж, түүнээс өөр хүнийг л Кежма руу дуудсан юм шиг хуучин янзаараа мэнд мэдэлцэнэ. Ингэхүйд мань хүн тосгоны хувьд болсон юм үнэхээр алга, өөрийнх нь явдал хэнд ч пад алга. Яаж тууж ирсэн яг түүн шигээ буцаагаад хөөгөөд явчих юм байна, энд түүн шиг амьтныг хэдэн зуугаар нь үзэж өнгөрүүлсэн юм байна гэдгийг ухаарна. Үхсэн, алагдсан, үрэгдсэн аль ч хүнд

дасчихсан, тусгай нүүдэлчдийн үр хүүхдийг хүртэл гэртээ оруулаагүй улс.

Хамтралын дарга Иван Парфёнович хүртэл Сашаг тоож анзаарахгүй, хэлэх газар нь хэлсэн, тэд нар л учрыг нь олдог юм байгаа биз, надад ямар ажил мундсан биш гэсэн шиг түүнийг хээвнэг харна.

Зидатай хэдэн удаа тааралдахад цаадах нь тэр бүрийд шалгаасан янзтай хардаг боловч мань хүн зогсож саатахгүй толгой дохиж мэндлээд өнгөрнө. Орой цонх нь гэрэлтэй харагдавч тэднийд эс очно. Хүүхнийг өрөвдөвч одоо түүнтэй мантай, ер нь хэн ч, юу ч падгүй байгаа тул өөрийгөө яаж ч чадахгүй байлаа.

Ганцхан Федятай энэ тэрийг ярьж аль нэг юм авахаар тэдний мухлагаар орж гарна. Федя урьдын адил нөхөрсөг харьцаж нэг удаа унадаг дугуйгаа засаж өгөхийг гуйжээ.

–За тэрийг ч больё, одоо та нарт би юу ч засаж өгөхгүй, өөрснөө янзалцгаа! гэж Саша хариулав.

–Сүүний машинаас болоод тэр үү? гэж Федя таамаглалаа.

–Тэгсэн байг л дээ!

–Тэгсхийгээд өнгөрөх ч юм билүү гэж Федя итгэл муутай өгүүлэв.

Саша хэрдхийн цочив. Ингэхлээр энэ явдал хараахан дуусаагүй гэдгийг тосгоныхон ойлгож байх нь. Өнгөрөх ч юм билүү... Эсвэл “өнгөрөхгүй” ч юм билүү. Хорлон сүйтгэх хэрэг тулгасан бол тийм амархан мултрахгүй гэдгийг мэдэцгээж байна...

–Өнгөрнө гэж би бодож байна хэмээн Федя арай итгэлтэй дуугаар өгүүлж, –Сүүний машин ажиллаж байгаа, МТС-д аваачаад үзүүлсэн чинь эрчлээс нь идэгдчихсэн байна гэж хэлсэн гэнэ билээ. Тэгэхлээр чинийхээр болсон хэрэг. Бас тэр чинь муу санадаггүй эр шүү гэв.

–Хэн?

–Манай дарга Иван Парфёнович чинь муу санадаггүй эр, эзэн хүн гэдгийг бас ойлгох хэрэгтэй шүү дээ. Хэрэм нүүчихсэн, хэдэн үнээ үхсэн, талх авчирч өгөхгүй байна, харчуулыг нь барилгын ажилд элсүүлж байна, нэмэрт нь авгай нарын аяыг бас олох хэрэгтэй. Гэтэл нөгөө авгайчуул чинь сүүний машинаас болоод хүний багалзуур тас хэмлэх нь халаг шаардацгаана. Тэр яахав дээ, нэг үг хэлээ л биз, чи тэвчвэл болох шүү дээ, гэтэл ихэрхсэн байгаа юм.

–За тэр яахав хэмээн Саша түүний үгийг тасдаж, –Папирос, шүдэнз өгөөд орхи, керосин хийчих, би явлаа.

–За Саша, гайгүй шүү дээ, дөнгөж гинж нь мултарчихсан юм. Би углаж чадахгүй байна. Дараа нь нэг нэг хундага татъя, утмал хадар бий, ингэхэд би чамд ямар муу юм хийсэн юм бэ? Би Иван Парфёновичид хүртэл та дэмий юм хийсэн байна, тэр чинь хот газрын, Москвагийн хун, сайн санасандаа л тэгсэн хэрэг гэж хэлсэн, авгай нарт ч бас хэлсэн, тэд нар ч дүлий

годил юм чинь дээ! Учир нь олдonoо, Саша...

–За яахав, тэр дугуйгаа үзүүл гэж Саша хэлэв. Федя түүнийг мухлаг дундуураа дагуулж хашаанд оруулаад модон байшингаас дугуйгаа гаргаж ирэв. Саша дугуйг задалж холхивч, араа, гинж, эрэг боолтыг үзэх зуур багад нь өөрт нь байсан янз янзын дугуйн эд ангийг цуглуулж хийсэн эмэгтэй хүний дугуйг санав. Мань хүн тэгэхэд эмээл дээрээ зогсох, буруу харж мордоод давхих, арагшаа үсэрч буугаад дугуйгаа доогуураа гаргах зэргээр дугуйг чадварлаг сайн унадаг байжээ. Максим Костин түүнийг даган гудамж хороогоор гүйнэ. Саша туунд дугуйгаа унуулахын зэрэгцээ заримдаа сундалж давхина. Эмэгтэй хүний дугуйнд дагуу холбоос байхгүй болохоор Максыг эмээл дээр суулгачихаад өөрөө зогсоогоороо дөрөөгөө жийгээд давхидагсан.

Саша дугуйнаас болж Клязьмад байдаг зусланг санав. Эрэгтэй, эмэгтэй олон хүүхэд дугуйтай, гэхдээ өөрийнх шиг нь юм цуглуулж босгосон биш, “Дукс”, “Эйнфильд” гэдэг сайхан дугуйнууд. Их үнэтэй дугуйнууд, гэхдээ тэнд “мэргэжилтнууд”, эмч, өмгөөлөгч гээд ядмаг бус хүмүүс амьдардаг байсан юм. Хүүхдүүд усанд орох гэж Клязьма руу, эсвэл арай өргөнийг бодож Уча руу дугуйгаар очицгооно. Зөрөг харгуй төмөр замын дагуу доошоо жалга руу нэг орж, дээшээ замын далан руу нэг гарч махирлах агаад түүгээр давхихад дугуйн дороос нарийн хайрга бутран үсэрч, нүүр лүү салхи алгадаж байдагсан.

Зуслангийнхан орой болохын үес буудлын тавцан дээр цугларч Москвагийн галт тэргийг хүлээн нааш цааш холхицгооно. Задгай энгэртэй зуны нимгэн даашинз өмссөн танхил авгай нар нөхрөө тоссоор костюмтай хүнд гар цүнхтэй буурьтай харчуулыг угтаж авна.

Хар үстэй, өргөн цээжтэй, жигд сайхан шарагдаж, бүсэлхийгээ хүртэл нүцгэлсэн Саша дугуйгаа хөтөлсөөр тавцан дээр ирнэ. Хүүхнүүд түүнийг инээмсэглэн харцгааж “Энэ хүрэл шиг хүүхэд чинь хэнийх вэ?” гэгцгээнэ. Сашад үүнийг сонсоход өег сайхан хэрнээ яльгүй түгшүүртэй санагдана. Ганцхан “хүүхэд” гэдэг үг шар хөдөлгөнө.

Оройн цагаар ойн цоорхойд нуугдаж тоглоцгооно. Урт шилбэтэй, өндөр туранхай охин, нэрийг нь бүр мартчихжээ, түүнтэй цуг нуугдаж санамсаргүй мэт шахан наалддагсан. Саша түүний хуурай халуун биеийг мэдэрч бие рүүгээ улам шахаж тэвэрмээр санагддаг боловч тэгж зүрхлэхгүй, дэмий л “Битгий хавьчаад бай, газар багадаад байна уу?” гэж загнана.

Эрийн сэрэл эрт үүссэн боловч тэр үед арван гуравтай байхдаа ийм хүслийг эр хүнд байж болшгүй дутагдал хэмээн үзэж түүнийг тэвчин унтрааж явжээ. Хашааны банди нар их зан гарган охидын тухай худлаа ярьж онгирохыг тэрээр жигшин дургүйцдэг бөгөөд үнсэх мөрийтэй тоглоом энэ тэрийг өөдгүй бэртэгчин явдал хэмээн түүнд эс оролцохдоо хүнд үүнээс арай эрхэм сонирхол байх ёстой гэж үздэг байжээ. Тэрээр биеэ голдоггүй зантай, хулчгар дорой харагдах дургүй хөвгүүн билээ. Сургууль дээр ч, хашаа хорооны хүүхдүүд ч түүнийг эрэлхэг зоригтой, сэтгэлийн тэнхээтэй гэж үздэг. Харин ийм харагдахын тулд дотроо ямар хүч гаргадгийг хэн ч мэддэггүй байжээ.

Сашаг тоохгүй болохоор нөгөө урт шилбэт охин Яша Рашковскийд наалдчихсан юм. Тэрээр Москвагийн алдартай бүжгийн жүжигчин айлын нэг гоолиг хөвгүүний нэрийг одоо хүртэл мартаагүй явна. Тэр хөвгүүн бас Их театрын бүжгийн сургуульд сурдаг, Сашагаас насаар нэг

юм уу хоёр ах, “Дукс” гэдэг уралдааны дугуйтай, үе тэнгийн дугуйчид дотор түүгээрээ ялгардаг байсан. Нэг удаа Уча руу биш Клязьма руу явж усанд орох санал тавьж, тэнд ус руу харайж ороход эвтэйхэн нэг газар олсноо хэлжээ.

Тэд Клязьмад ирж дугуйнаасаа бууцгаан хувцсаа тайлж эрэгтэй эмэгтэйгүй усанд орох хувцастайгаа үлдсэн хэрнээ ганцхан Яшка л ус руу үсэрчээ. Үнэхээр ус руу өнгийсөн эвтэйхэн эрэг боловч арван хоёр метр хэртэй тун өндөр эрэг тул охидууд тэнд босоо байхаасаа хүртэл айж ирмэг дээр нь хэвтэж байгаад ус руу тонгойж харна. Дэндүү өндөр учраас хөвгүүд харайхаасаа зүрхшээн байв. Яшка номхон зогссон янзаар ус руу харайж тэр чигээрээ далд орсноо шоволзон ил гарч, налуу эргийг чиглэн гараараа хол хол самран сэлж ирээд ташуу зөргөөр өгсөн дээшээ гарч ирэв. Охидууд түүнийг шагшин харцгааж, урт шилбэт ч мөн л шагшиж байв. Яшка Рашковский хүмүүжил сайтай хүүхэд болохоор харайсандаа онгирч хөөрсөнгүй, бусдыг харайлгах гэж битүүгээр цаашлуулсангүй, нуруугаа наранд ээхээр түрүүлгээ хараад элсэн дээр хэвтээд өгөв.

Саша дамжуурга, завь энэ тэрээс ус руу үсэрч байснаас биш өндөр тавцан буюу эрэг дээрээс харайсан удаагүй юмсанжээ. Гэвч Яшкаг харайчихаад байхад өөрөө яагаад чадахгүй байх билээ? Харайх хэрэгтэй, айдсаа давах хэрэгтэй. Сэлэх, шумбахын аль алинд нь сайн юм чинь гол нь биеэ хөвчлөн цэх байлгаж гэдсээрээ юм уу, нуруугаараа палхийтэл ойчилгүй өлмийгөөрөө ус руу орох хэрэгтэй. Өрсөлдье гэсэн санаа биш өөрийнхөө айдсыг давах хүсэл тэмүүлэл оргилон байв. Тэрээр харайхгүй байлаа гэхэд сэтгэлийн зовлонд унаж, эрт орой хэзээ боловч ийшээ эргэж ирж харайна. Тэгсэнд орвол одоо харайсан нь шулуун.

Тэрээр босож суниалаа...

–Нэг шумбая байз...

Эргийн ирмэг рүү нэгэнтээ алхаад үсэрсэнд ус руу яггүй гүнзгий орчихов. Тэгээд бачимдаж яаран хэд самардтал усны гадарга дээр гарчихсан байсан тул гэдэргээ харж хэвтээд амьсгаагаа дарлаа... Эрэг дээрээс түүн рүү харж буй олон хүүхдийн дотор Яшка, урт шилбэт хоёр бас байлаа...

Хүүхэд ахуй цагийн энэ дурсамж дотор улам уймруулна. Юуны төлөө сэтгэлээ чангалах сургууль хийж, юуны төлөө эрмэг шулуун зантай болох гэж мэрийж явсан юм бэ? Түүнийг нэг хүн дуудсанд Зидагийн дуу гэж таниад эргэж харвал тэрээр үүднийхээ довжоон дээр зогсож байв.

–Федягийн ээжийнхээр орж, эм аваачиж өгөөд явж байна.

Зида Кежмаас эм авчирч тосгоныхныг эмнэж тэдэнд чадах чинээгээрээ тусалдгийг Саша мэднэ. Бас сурагчид нь хичээлээ таслах буюу сургуулиа бүр хаядаг, сургуульд өөрт нь сурах бичиг, дэвтэр тэр ч байтугай харандаа дутагдаж байдаг энэ тэрийг мэднэ. Зида Кежмаас юухан ч болсон олох гэж хөөцөлдөнө, юу ч олохгүй бол байгаа юмаараа аргацаахын хамт айлуудаар орж хүүхдээ сургуульд нь буцааж явуулахыг эцэг эхэд нь ятгаж, заримдаа санасандаа хүрдэг боловч заримдаа хэрэг нь эс бүтнэ. Зовлон тоочиж үглэхгүй, тэсвэр хатуужилтай сайн хүүхэн, гэхдээ энэ бөглүү газар юуны төлөө ингэж сайн дураараа тарчилж

байна вэ?

–Орж гарахгүй яачихаа вэ? гэж Зида аяархан асуув.

–Ямар ч урам алга.

–Сашенька, би санаад байна, манайд очоорой...

–Хүн амьтан харчихвал чи сайнаа үзэхгүй. Шөнө орой болтол хэний төлөө гэрэл асааж керосин барж байгааг чинь улс ойлгохгүй байгаа гэж бодож байна уу?

–Би гэрэл асаахаа байя. Бүрий болмогц хүрээд ирээрэй. Шинэхэн загас шараад бин хайраад байна шүү.

Бүсгүйн дотносог зан, дуу хоолой, түүний хэрэглэдэг хямдхан сүрчигний танил үнэр энэ тэр Сашагийн сэтгэлийг хөдөлгөнө.

–Би Федятай юм балгана, яаж согтуу очих вэ дээ?

–Ямар ч байсан хүрээд ир л дээ.

–Энэ тэнэг явдлын тухай бүү бод, битгий өөрийгөө зовоо хэмээн Зида өгүүлээд,

–Алфёров МТС-д очиж сүүний машиныг зас гэж хэлсэн, цаадуул нь яг тэр өдөр нь янзалчихсан. Тэр чинь өөрөө элдэв хэрэг болгож дэврээхийг хүсэхгүй байгаа юм гэв.

–Чи яаж мэдээ вэ?

–МТС-ын дарга надад хэлсэн, би авгайтай нь үерхдэг юм.

Сашаг тайвшруулах гэсэндээ ийм юм зохиожээ. Алфёров МТС руу очиж сүүний машины тухай сонирхсон байж магадгүй, харин шуурхай засварлахын тухайд бол Зида өөрөө даргаас гуйсан байх. Тэрээр Зидад,

–Энэ явдал барагдсан ч бас нэгийг зохиочихно. Зохиох юмаа олно гэж хэлэв.

–Чамд тохиолдсон явдал бол санамсаргүй зүйл, энд хэзээ ч тийм юм болж байгаагүй.

Саша гэнэтхэн,

–Хөөе, чиний тэр танил дарга чинь намайг МТС-даа татаад авчихаж болохгүй юм уу? Тэдэнд бодвол хүн хэрэгтэй байлгүй гэв.

Тэрээр тохойлдон өндийж мань хүн рүү харахад тун ойрхон байгаа нүүр нь жижигхэн цонхоор туссан сарны гэрэлд ер бусын цав цагаан харагдав.

–Чи Кежма руу шилжмээр байна уу?

–Хонгор минь, би чинь ямар нэг юм хийж ямар нэгэн орлогоор амь зуух хэрэгтэй биз дээ?

Хүүхэн буцаж дэрээ дэрлээд чимээгүй болов. Сашаг Кежма руу явуулах дургүй, түүнийг алдахаас айж байх нь. Томоогүй ч амьтан бол доо, тэртэй тэргүй алдах юм чинь. Мань хүн хугацаагаа хал балгүй дуусгалаа ч гэсэн суллагдсан хойноо хэн нэг хүнтэй ирээдүйгээ холбох эрхгүй байх билээ. Шүүхээр ял шийтгүүлсэн нэр үүрд хадагдаж, тэрээр дьяковчуудын байнгын хараанд байх учраас бас нэг хүний хувь заяа, бас нэг хүний амьдралын хариуцлагыг өөртөө авч, Зидаг хэрэн тэнүүчлэх, зовон тарчлах замд яаж оруулах вэ! Нэгэнт ийм им тамгатай болсон хойно хамаг хуучин харилцаа холбоогоо тасалж ул мөргүй уусан арилж үгүй болохоос өөр зам байхгүй. Тэрээр цаашид орь ганцаараа байх ёстой. Өөрийнхөө амь насыг хамгаалж чадах уу, үгүй юу гэдэг нь бүү мэд. Харин хоёр хүнийхийг хамгаалж чадахгүй нь лав.

–Би тоглосон юм, миний тухай гуйхын хэрэггүй. Ажилд тэртэй тэргүй авахгүй. Түүнээс гадна Кежмад байвал ямар нэг хэрэгт холбогдох бололцоо л нэмэгдэнэ. Тэнд юу л болсон над руу чихчихнэ гэж Саша өгүүлэв.

Зида харанхуйд гараа сунгаж түүний толгойг тэмтэрч олоод илбэх зуур,

–Битгий гутар, чи залуу хүн. Хамаг амьдрал чинь чамайг хүлээж байна. Одоо хичнээн үлдсэн билээ? Хоёр жил биз дээ гэв.

–Хоёр жил дөрвөн сар гэж Саша заслаа.

–Сашенька минь, тэр чинь дорхноо өнгөрчихнө. Суллагдаад л яваад өгнө шүү дээ.

–Хаашаа? хэмээн Саша асуугаад, –Намайг Москвад оруулахгүй. Тэгэхлээр дахиад тэнүүчлэх хэрэг болно, зүгээр ч үгүй тавин наймдугаар зүйлийг давсан хүн шүү дээ гэв.

–Чи нэг тийшээ яваад өгвөл яасан юм бэ, жишээ нь манай Томск муж руу...

Бүсгүй санаагаа дутуу хэлэх шиг Сашад санагдав.

–Тэглээ гээд юу болох вэ?

–Тэнд чамайг мэдэхгүй шүү дээ... гэж Зида хариулахад бас л хэлэх гэсэн юмаа шууд хэлж зүрхлэхгүй байгаа нь мэдэгдэв.

–Тэгэхлээр ийм шүү дээ, паспортанд миний овог нэрийг тодорхой бичнэ, бас ял шийтгүүлсэн тухай тусгайд нь тэмдэглэнэ. Яаж хийх нь заавартай. Паспортын “Ямар баримт бичгийг үндэслэн олгосон” гэсэн хүснэгтээр “ЗСБНХУ-ын Ардын Комиссарын Зөвлөлийн... тэдний өдрийн тогтоолын II зүйлийг үндэслэн” гэж бичдэг юм. Тэр нь паспортын систем болон түүний хязгаарлалтын тухай тогтоол. Ингэхлээр би Томск, Омск гээд хаашаа ч явсан нэгэнт ял эдэлсэн хүн гэдэг тодорхой. Чи ойлгож байна уу?

–Ойлголоо, гэхдээ паспортыг чинь үрэгдүүлж болно шүү дээ.

Саша инээд алдав.

–Хэрвээ тэр чинь тийм амархан юмсан бол ял эдэлсэн бүх хүн паспорт, ял хоёроосоо аль хэзээний хагацчихсан байхгүй юу. Одоо хэр тэгж чадсан хүн байхгүй байх гэж бодож байна. Шинэ паспорт олгохдоо шаардлагатай газраас асууж лавладаг, тэгээд бүх юмны ны учир мэдэгддэг юм.

–Тэнд надад танилууд бий, юу ч хийгээд өгсөн чадна.

–Би хууль бусаар авсан хуурамч паспортаар амь зуух бодолгүй байна.

–Бүх юм хууль ёсоор хийгдэнэ, зөвхөн овгоо л солих хэрэг гарна.

–Яаж солих билээ? Сонин юм байна.

Зида дахин тохойлдож өндийгөөд түүн рүү тонгойв.

–Хэрвээ цөллөгийн дараа чи бид хоёр эндээс явж, тэнд очоод бүртгүүлэх юм бол чи хууль ёсоор миний овгийг авч болно, тэгвэл чамд шинэ паспорт олгоно шүү дээ. Тэгээд чиний яриад байгаа тэр хүснэгтэд “Гэрлэлтийн баталгааг үндэслэн олгосон” гээд биччихнэ. Панкратов биш Исхаков л болно, бас ч гэж муугүй шүү.

–Тэгвэл лалын сүсэгтэн болох нь ээ хэмээн Саша инээд алдаж, –Огтолдог ёсоо надад албадаж хийх үү? гэв.

–Би чамтай тоглоогүй шүү. Надад тэнд найдвартай хүмүүс бий.

–Чи үүнийг сая бодож олов уу?

–Би бүх насаараа Сибирьт аж төрж байгаа хүн, хүмүүс ингэдгийг мэднэ. Би чамд наалдчих гэж тулгаж байгаа юм биш байдлаас яаж гарсан нь дээр вэ гэдгийг л зүгээр бодож байна. Харин дараа нь чи хүсвэл хоёулаа салчихаж болно, чи Исхаков чигээрээ л үлдэнэ биз. Гэхдээ цэвэрхэн паспорттай хоцорно. Надаас талак болно биз.

–Талак гэж юу вэ?

–Татараар “салах” гэсэн үг. Нөхөр нь авгайгаа хөөх болбол талак гэдэг үгийг гурвантаа хэлдэг юм.

Хөөрхий Зида өөрт нь аз жаргал ирнэ гэж бодож байна, гэвч тэр хоёрын хэнд нь ч аз жаргал ирэхгүй. Тэрээр хүний нэрээр, хүний паспортаар оргодол шиг амьдрахыг түүнд санал болгож байна. Тэгэхлээр мань эр хэзээ нэгэн цагт, хаа нэгэн газар танил хүнтэйгээ тааралдвал өөрөө Панкратов байхаа аль хэдийн больж Исхаков болсон, хүнтэй ханилснаас тэр гэж учирлан тайлбарлаж байх ёстой болох нь. Түүнээс гадна дьяковчууд яаж ийж байгаад түүнийг оллоо гэхэд эхнэрийнхээ ард нуугдахыг оролдоо шив, найз минь, биднээс хэний ч ард нуугдаад нэмэргүй гэж бахаа ханган тавлах болно. Бас тэгээд хуурамч паспортаар амьдарч байгаа чинь санаандгүй хэрэг биш, үнэнч шударга зөвлөлтийн хүнд хуурамч паспортын хэрэг байхгүй,

үнэнч шударга зөвлөлтийн хүн овгоо сольдоггүй юм гэх вий.

Гэвч энэ бүхнийг Зидад тайлбарлах хүсэл байсангүй. Түүнийг гомдоохын хэрэг юу байх вэ.

–Зида, чи бод доо, ажилд орохын цагт маягт бөглөж намтраа бичиж хаа төрсөн, хаана сургуульд суралцсан, эцэг эх хэн бэ, өвөө эмээ хэн бэ гэдгийг бичих хэрэгтэй болно. Панкратовыг яагаад ч нууж хааж чадахгүй. Ийш тийш нь сураг тавиад л бүх юм тодроод ирнэ.

Зида өөрийнхөөрөө зүтгэж,

–Аль нэг алсын район руу яваад өгье, жолооч юм уу механикчаар ажиллана биз, тийм хүмүүсээр маягт бөглүүлдэггүй, асууж сурагладаггүй юм гэв.

–Больж үз, бидний яриа ямар ч утгагүй болох тийшээ хандаж байна. Би энэ овогтой төрсөн, мөн тэр чигээрээ үхнэ. Өөрчлөх юм байхгүй гэж Саша эрсхэн хэлэв.

Санхүүгийн байцаагч Костяг орлого нуусан хэмээн буруутгаж ихээхэн хэмжээний албан татвар ноогдуулжээ. Төлөхгүй бол шоронд орно. Эхлээд эд хөрөнгөө Клавдия Лукьяновна гэдэг хуучин авгайнх нь юм гэж зүтгэсэн боловч Сокольникт буй оршин суугаа газрынх нь хаягаар өөрийнх нь нэр дээр бүртгэж авчээ. Түүнийг эхнэрээсээ салаагүй хүн гэдгийг Варя ингэж мэджээ.

Хэрвээ Костя гэр бүлийн баталгаатай, салсан бичиг баримтаа бүрдүүлж амжаагүй гэж эхнэрээсээ өөрт нь хэлсэн бол Варя үүнийг төдийлөн тоохгүй байсан билээ. Гэтэл мань хүн үүнийгээ нууж, чухам тэр учраас паспортаа үзүүлэхгүй байж. Ийм заль бол доромжлол. Варягийн үл мэдэх Костягийн өөр нэг амьдралын тухай анхны дохио энэ.

–Ляленька, би ингэхээс өөр яаж ч чадаагүй юм хэмээн Костя мэтгэж, –Би зөвхөн Москвад суух зөвшөөрөл олж авах гэж л Клавдия Лукьяновнатай гэр бүл бүртгүүлсэн юм, бас их мөнгө төлснийг яана. Чамайг ойлгохгүй гэж айгаад би энэ тухай чамд яриагүй юм. Гэхдээ ийм наймаа мянга мянгаараа бий, байхгүй бол хүмүүс Москвагийн зөвшөөрөл олж чадахгүй байхсан. Клавдия Лукьяновнагаас бичиг баримтаа салгахын тулд би аль нэг газар суурьших зөвшөөрөл олсон байх ёстой. Хаана? Хэнийд? Хэн намайг дэргэдээ авах вэ? Софья Александровна юу? Хэн түүнд зөвшөөрөх юм бэ? Танайд байх зөвшөөрөл авах уу? Нина үүнийг зөвшөөрөхгүй, тэр чинь намайг тоодоггүй хүн гэв.

–Тэгээд ямар арга байна? Клавдия Лукьяновна чиний албан ёсны эхнэр, би жинхэнэ эхнэр чинь байх хэрэг үү? гэж Варя асуув.

Костя царай алдангуй янзтай,

–Би Шинжлэх ухаан академийн нэг эрдэм шинжилгээний хүрээлэнд цахилгааны маш нарийн тоноглол хийж байгаа. Тэднийх ажилтан нартаа зориулж орон сууцны байшин барьж байгаа, тэгээд надад нэг өрөө өгөхөөр амласан юм гэж өчив.

Костя Шинжлэх ухааны академи, хүрээлэн, нарийн тоноглол... гэхчлэн урьдын адил тун нухацтай өгүүлсэн боловч Варяд төдий л үнэмшилтэй санагдсангүй.

–Өрөө өгөх бодолтой юм бол эхлээд орон тоондоо авах ёстой шүү дээ.

Костя уруулаа цорвойлгон үгээ сунжруулж,

–За яахав... Уул нь ярихгүй гэж бодсон юм, гэвч шаагдаж байна... Чи юу гэж бодож байна? Намайг хөөрхөн нүдтэй гэж захиалга өгдөг хэрэг үү? Үгүй шүү, Ляленька! Би захиалсан хүнд тэн хагасыг нь өгдөг юм. Тийм учраас тэд өөрсдийнхөө хувийг авахын тулд намайг гэрээгээр аргамжиж байх ёстой болдог, томоохон гэрээгээр шүү, гэхдээ тэр тоо цаасан дээр л том байгаа юм, тэн хагасыг нь би тэдэнд өгчихдөг. Гэтэл албан татварыг бүх дүнгээс нь бодож төлж байна, тэгэхлээр надад юу үлдэх вэ? Юу-уу-ч үлдэхгүй! Улаан мөнгө ч үлдэхгүй! Тэгвэл чи бид хоёр чинь ямар нэг орлогоор аж төрөх ёстой биз дээ. Иймэрхүү байдлаас болоод л би мэдэгдлийн хуудсанд аль нэг эмнэлгийн холбоотой хоёр цөөхөн орлогоо бичээгүй юм.

“Санхүү” энийг л өөрчилж байна. Чи надад итгэ! Энэ бүх ажлыг би аль хэдийн хаявал хаях л байсан. Зөвхөн өрөө горьдсондоо л тэр хүрээлэнтэй зууралдаад байлаа л даа. Чи бид хоёр гэр бүлээ батлуулаагүй байсан нь л яамай боллоо, тэгсэн бол хөрөнгөний бүртгэл гаргахаар чам руу ирэх байж шүү гэж үглэв.

–Клавдия Лукьяновна яах вэ?

–Клавдия Лукьяновна юу гэж?

–Яалаа гэж тэднийд эд хөрөнгийг бүртгэж байна?

–Клавдия Лукьяновнагийн тухайд чи санаа бүү зов. Тэр чинь биеэ өмгөөлөхтэйгөө хүн, энэ байтугай юманд орж явсан толгой. Хэний ч тухай, юуны ч тухай бүү санаа зов, бүх юмны учир олдоно. Тэгээд аяндаа өнгөрнө. Би аль нэг юм дутуу хэлж байгаа бол чамайг тайван байлгая гэсэндээ л тэр, миний хувьд чамайг тайван байлгахаас өөр чухал юм алга!

Тэрээр зөндөө удаан ярив. Хэн нэгэн хүнд ямар нэгэн юмыг ятгаж үнэмшүүлэх хэрэгтэй бол үг нь мянга мянгаараа ундарч, шалтаг зуу зуугаар нь тоочдог хүн л дээ.

Варя түүнд итгэж байгаа билүү? Итгэхийг хүсэж л яваа, эс тийм бол түүнтэй яаж цуг амьдрах вэ? Гэвч хэнээс ч хамаарахгүй хүн гэж байдаггүй юм байна, Костя ч гэсэн яг тийм л хүн, аягүй бол Костя бусдыг бодвол хүнээс улам ч их хамаардаг байж мэдэх юм гэж Варя харуусан бодно. Лёвочка өөрийнхөө албан ажлаас хамаарна, тэр ажил нь шалихгүй ч гэсэн хууль ёсны ажил, бас өөрийнхөө цалингаас хамаарна, тэр нь өчүүхэн ч гэсэн хууль ёсны цалин. Костя бол хэдэн зуун нөхцөл шалтгаанаас хамаарна, үүнийг алхам тутамд нь аюул отоож байгаа. Өнөөдөр баян хүн л явж байна, маргааш гэхэд ядуугаас ядуу болчихно, өнөөдөр амьдралын оргил дээр явж байна, маргааш гэхэд бүр адгийнх нь ёроолд шидэгдсэн байж ч мэднэ.

Костя нөгөө явдлаас яаж бултаж гарсныг Варя мэдэхгүй байв. Гэхдээ ямар ч атугай мултарчихсан бололтой. Тэрээр хоёр долоо хоног гэрээрээ бараг үзэгдэлгүй, ресторан, бильярдын газраар ч ер оролгүй, энэ хугацаанд Варяд үл мэдэгдэх улайрсан үйл ажиллагаа явуулсны эцэст бүх татвараа хуу төлж дөнгөлөө гэж түүнд хэлжээ. Харин артельтай дахиад ярих юм нэгэнт үгүй болсон аж. Одоо Костя ямар төлөвлөгөөтэй байгааг Варя эс мэднэ. Энэ тухай цаадах нь ч хэлдэггүй, өөрөө ч асуудаггүй билээ.

Костя Герцений гудамжинд байх бичгийн машин засах газар ажилд орсон гэхээс өөр юу ч хэлсэнгүй. Бичгийн машиныг мань хүн мэдэхийн цаагуур мэднэ. Варяд засварын газрын утасны дугаарыг өгөхдөө өөрийг нь олж утасдахад их хэцүү, өглөөний арван цагаас эхлээд бичгийн машин засахаар элдэв албан газраар яваад өгдөг, заримдаа урьд өдөр нь ажлын захиалга ирвэл тэр газрууд руу нь өглөө шууд гэрээсээ явчихдаг гэж анхааруулжээ. Костя тэр засварын газар зөвхөн бүртгэлтэй, түүний ажлыг бусад засварчин хийж, мөн төлөөнөөс нь цалингийг нь авдаг гэдгийг Варя тун удалгүй гадарлаж, төдөлгүй яг үнэн болохыг мэдэв. Энэ нь Костяг бичгийн машины засварын газрын ажилтан гэсэн албан ёсны нэр олгоно.

Хийдэг ганц ажил, орлого олдог ганц зам нь бильярд, гагцхүү бильярд болсон байжээ.

Варя ингээд бүх юмыг ойлгосон үедээ ажилд оръё гэж бүрэн шийджээ.

Лёвочка, Рина хоёр Варяд туслахаар амлацгаажээ. Тэд нар Зоягийн ажилладаг нөгөө “Москва” зочид буудлын зураг төсөл боловсруулах товчоонд ажилтай. Зураг хордуулан буулгагчид хаа сайгүй хэрэгтэй, самбар болгон дээр тийм зарлал өдий төдийгөөрөө байгаа юм чинь Варя уул нь хэн нэгний гар харалгүйгээр ажилд орвол чадах л даа. Гэхдээ өөрснийхөнтэйгөө ажиллах нь дээр. Лёвочка, Рина хоёр “Москва” зочид буудлыг шууд Москвагийн Зөвлөлд захирагддаг, нийслэлийн хамгийн том чухал барилга, бас нэмэгдэл цалинтай, их сайхан гуанзтай гэгцгээжээ. Шинэ барилгыг “Гранд-отельтэй” холбох агаад тэгсний дараа энэ нь Европын хамгийн том буудлуудын нэг болно. Тэдний товчоонд хамгийн сайн уран барилгачид, зураачид, инженер, техникчид ажиллаж байгаа гэнэ. Лёвочка, Рина хоёр тухайлбал өөрсдийнхөө удирдагчийг магтана. Тэр нь Игор хэмээх хачин нэртэй залуухан авьяаслаг уран барилгач, зочид буудлын зураг төсөл зохиогчдын нэг бөгөөд халамж анхааралтай, тусархаг сайн хүн ажээ. Хэрвээ Варя сайн ажилладгаа харуулах юм бол Игор Лёвочкаг дэвшүүлсэн шигээ түүнийг дэвшүүлье гэвэл дурын хэрэг. Лёвочка одоо техникч хийж байгаа л даа. Рина ч бас удахгүй тийм болно. Товчоо нь Охотный ряд гудамжны “Гранд-Отелийн” тавдугаар давхарт байрладаг тул тэдний Арбатын байрнаас ердөө долоохон буудал, бас дөрөвдүгээр, арван долдугаар ноймерын хоёр янзын трамвай явна. Зоя энэ байдлыг бүр ч онцлон ярина. Тэрээр мөн энэ товчоонд, гэхдээ өөр хэлтэст ажилладаг юм.

Лёвочкагийн товчосон өдөр Варя “Гранд-Отельд” ирэв.

Охотный ряд гудамжинд “Гранд-Отель”, Манеж хоёрын хооронд байсан олон мухлаг, бяцхан сүм, бусад барилгыг хуу нурааж, газар дээр нь хашаа тойруулан барьжээ. Варя зочид буудал руу Воскресений талбайн талаас оров. Дүрэмт хувцастай хаалгагч түүнийг дагуулан харсан боловч хашаа очиж яваа нь асуусангүй. Таван давхарт гаргаж өгсөн цахилгаан шатны үйлчлэгч ч юу ч асуусангүй.

Варя цахилгаан шатнаас гараад Лёвочкагийн зааж өгсний дагуу зүүн гар тийшээ эргэж, энэ давхар буудал байх үеэс хоцорсон хаалганы дугаарыг ээлжлэн харсаар урт хонгилоор алхлав. 526 тоотыг олмогц хаалгыг онгойлголоо.

Яг ийм өндөр адартай, нарийхан урт цонхтой өрөөнд Костя тэр хоёр Ялтад “Орианда” буудалд байхдаа сууж байсан билээ. Ялгаатай нь гэвэл буудлын тавилгын оронд энд гурван энгийн ширээ байх бөгөөд дээр нь хазгай ивээстэй зургийн самбар тавьжээ.

Цонхны харалдаа ажиллаж байсан Лёвочка Варя руу эргэж соёгор шүдээ орсойлгон найрсаг инээмсэглээд зургийнхаа үзгийг тавив.

–Хүрээд ирэв үү? Сайн байна!

–Рина хайчаа вэ?

–Гарсан. Одоохон ирнэ. Дипломаа авчирсан уу? Тэрээр Варягийн сургууль төгссөн гэрчилгээг гүйлгэж харав.

–Жин тан! Явья!

Хажуугийн өрөөний хаалгыг онгойлгов.

–Орж болох уу, Игорь Владимирович аа? Тэгээд хариу хүлээлгүй Варяг дагуулан орлоо. Варя энэ нэрийг сонсонгуут хоромхон зуур бүх юмыг ойлгов. Үүнээс өмнө яагаад санаанд орсонгүй вэ? “Игорь” гэдэг нэрийг л Игор болгоцгоочихсон юм байна. Энэ хүнийг “Националь” ресторанд Викагийн танилцуулж өгсөн нөгөө Игорь Владимирович гэж даанч бодоогүй билээ. Эртхэн шиг үүнийг ойлгосон бол Варя ийшээ огт ирэхгүй байх билээ. Гэвч нэгэнт оройтжээ. Игорь Владимирович түүнийг харангуут таньж гайхсан янзтай нүд нь том болон ширээний цаанаас босож ирээд эелдэгхэн хэрнээ гайхсан, тэр ч байтугай яльгүй самгардсан янзтай инээмсэглэн байв.

–Игорь Владимирович аа, миний танд яриад байсан нөгөө охин чинь энэ, Иванова гэдэг иргэн гэх юм уу даа, дипломтой хүн. Варя, дипломоо үзүүл гэж Лёвочка хэллээ.

Варя дунд сургууль төгссөн гэрчилгээгээ цүнхнээсээ дахин гаргаад ширээн дээр тавив.

Игорь Владимирович суудалдаа буцаж суух зуур,

–Та суу л даа гэж Варяд хэлэв.

–Би ч явах уу даа? гэж Лёвочка асуув.

–Тэг тэг, баярлалаа...

Лёвочка гарлаа.

Игорь Владимирович Варягийн гэрчилгээг уншиж үзэв.

–Та аль нэг газар ажил хийж байсан уу?

–Үгүй.

–Нээрэн ч тийм юм даа, энэ гэрчилгээ чинь дөнгөж гурван сартай юм байна хэмээн Игорь Владимирович инээмсэглээд, –Яасан санаандгүй уулзалт вэ? Лёва надад таны тухай ярьж, авах нь л зүйтэй гээд байсан юм, би таныг гэж даанч бодоогүй шүү гэв.

–Би ч гэсэн тантай уулзана гэж огт бодсонгүй гэж Варя өгүүлэв.

Анхны тулгамдаж цэрвэсэн байдал арилсан боловч яагаад ч юм бэ, нэг л гунигтай болчихов. Варя Игорь Владимировичийг гурав билүү дөрвөн сарын өмнө цорын ганцхан удаа үзсэн атал түүнээс хойш хязгааргүй их хугацаа өнгөрсөн мэт санагдана... Александрын цэцэрлэгээр зугаалсан, Бовегийн тухай ярилцсан, манаачаас зугтсан, оймсоо урсан энэ тэр чинь мөн ч эрт болсон явдал биз дээ.

–Та жаахан хувирчээ, хувирах юу байх вэ, яльгүй байр суусан байна гэж Игорь Владимирович

ХЭЛЭВ.

–Би хүнтэй суусан гэж Варя өчив. Ингэж хэлснээр тэр хоёрын харилцаа ямар байх ёстойг тов тодорхой болгож байх шиг түүнд санагджээ.

–Тийм мэдээ миний сонорт хүрсэн шүү гээд Игорь Владимирович инээмсэглэв.

“Викагаас дуулжээ” гэж Варя дотроо бодов.

–За тийм байж, ажлаа ярилцъя хэмээн Игорь Владимирович ажил хэрэгч өгүүлээд, — Та урьд нь ажил хийж байгаагүй болохоор хордуулан буулгагчаас эхлэх ёстой гэв.

–Би энэ тухай мэднэ ээ.

–Та зурах дуртай юу?

–Дуртай.

–Сайн байна. Хоёр зүйлийн боломж байна, эсвэл зураг буулгах нийтийн урлангийн газар, эсвэл манай хэсэгт Лёвочка, Рина хоёртой ажиллаж болно. Аль нь танд дээр вэ?

Варя нийтийн урлангийн газар Зоягоос өөр таних хүнгүй учир тэнд ажилламааргүй, эндээ Лёвочка, Рина хоёртой ажилламаар байв. Гэтэл энэ нь Игорь Владимировичийн хажууд түүний удирдлагын дор ажиллана гэсэн үг. Уул нь энэ хүн өөрт нь хэн ч биш гэдэг нь мэдээж, ганц нэгхэн цаг “Национальд” цуг сууж, Александрын цэцэрлэгээр нэг дайрч, хэдэн үг солилцсон төдий... Варя одоо нөхөртэй хүн, тэглээ ч гэсэн Игорь Владимировичид аятайхан санагдаж буйгаа мэдэрч, түүний ичингүйрэн бүхийг харж байгаа болохоор тэр хоёр цуг ажиллахад эвгүй юм. Тийм учраас Варя,

–Мэдэхгүй байна. Надад ялгаа алга гэж хариулав.

–Манайхаас эхэл дээ, эхний үес найз нартайгаа Лёва, Рина хоёртой цуг байхад танд амар байж таарна. Тэгээд зүгширснийхээ дараа байдлаа харж байгаад хаана дээр вэ гэдгээ шийднэ биз. Тэгэх үү? гэж Игорь Владимирович санал болгов.

Варя зөвшөөрч буйгаа илэрхийлэн толгой дохив.

Игорь Владимирович түүнд хуудас цаас үзэгтэй өгч ажилд орох тухай өргөдөл дуудаж бичүүлэв. Тэгээд уншиж үзсэнээ Варягийн гэрчилгээнд хавсарган бичгийн хавчаараар хавчаад суудлаасаа босон нөгөөдүүлээ барьсаар зэргэлдээх өрөөний хаалгыг нээж Варяг түрүүндээ авч оров. Тэнд Лёвочкагаас гадна Рина бас ирчихсэн мань хүн рүү сайшаан нүд ирмэж байв.

–Лёва, би удахгүй буцаад ирнэ. Чи одоохондоо Варяд ажил байдлаа танилцуулж бай гэж Игорь Владимирович хэлэв.

Түүнийг гармагц Рина инээд алдав.

–Харав уу, чамайг мөн хүндэлж байна шүү, өөрөө бичиг баримтыг чинь бүрдүүлэх гээд явчихлаа.

–Боловсон хүчнийхэн үүнийг айлгачихна гэж санаа нь зовоо биз. Бүх юм жин тан болно. Рина техникчийн албан тушаалд шилжиж байгаа, тэгэхлээр чи оронд нь миний удирдлагын дор хөдөлмөрлөх болж байна гэж Лёва өгүүлэв.

Рина түүнийг Игорь Владимировичтай “Национальд” цуг байхыг харсан юм чинь битүүдээ тэр тухай өгсөн юм биш биз?

–Намайг нийтийн урлангийн газар очихгүй юу гэж байна лээ хэмээн Варя өчиж Ринагийн битүү санааг няцаав.

–Хачин юм даа, уул нь чамайг бидэнтэй ажиллууна гэж бид хоёр тохирсон юмсан. Би бас Костяд ч ам өгсөн юм гэж Лёва хэлэв.

–Чи Костяд юу амласан юм бэ? Намайг мөрдөнө гэж амлаа юу?

–Хаанаас даа, Варя, яах гэж тэгэх билээ? Зүгээр л эхний үед чамд тусална гэж амласан юм... За тэр ч яахав! За чиний ширээ энэ байна, самбар, чигтэй шугам энэ тэрээ харж ав, зургийн хэрэглэлээ нярваас аваарай.

–Өөрийн хэрэглэлтэй болтлоо тэр шүү гэж Рина тайлбарлав.

–Тэр бол хожим, их мөнгө авдаг болохоороо хийх зүйл хэмээн учир мэдэх Лёва өгүүлээд, — Манай сангийн хэрэглэлээр ажиллахад ер дажгүй гэв.

Тэрээр босоо шүүгээг нээж зургууд болон өөр хаа юу байгаа, хаанаас юу авахыг үзүүлэв. Рина завсраар нь инээдэмтэй үг нэмэрлэж, ер нь аятайхан, эвлэгхэн, хөгжүүхэн байлаа.

Тэднийг иймэрхүү байдалтай байхад Игорь Владимирович орж ирэв.

–Танилцаж байна уу?

–Тэгэлгүй яахав.

–Варя, над руу түр ороод гараач.

Тэр хоёр тэдний өрөөнд буцаж ирэв. Игорь Владимирович өөрөө сууж Варяг урьж суулгаад,

–Таны өргөдлийг даргаар цохуулчихлаа, маргааш өглөөнөөс ажилдаа ороорой. Май, таны дипломыг өгчихье. Бас үүнийг... гэв.

Тэгээд сургууль төгссөн гэрчилгээнийх нь хамт дөрвөн хуудастай том маягт өгөөд жуумалзав.

–Үүнийг та гэртээ бөглөчихөөд маргааш аваад ирээрэй, боловсон хүчний хэлтэст өгөх юм. Та анх удаагаа ажилд орж байгаа болохоор ийм маягттай тааралдаж яваагүй байх, үүнээс

Тэнэг юм бодож олно гэхэд бэрх, гэвч албаны журам ийм хойно дагахаас өөр аргагүй. Таны эцэг эх сэрүүн тунгалаг уу?

–Байхгүй.

–Өө тийм үү. Тэгвэл зүгээр л тэдний нас барсан он, сар, өдрийг биччихээрэй, тэдний тухай өөр юу ч бөглөхийн хэрэггүй. Бас нэг асуулт байна... Та намайг зов ойлгоорой, албан ажлын шаардлагын үүднээс л асууж байгаа юм шүү. Та нөхөртэйгөө гэр бүлээ батлуулсан уу?

–Үгүй.

–Яагаад үүнийг асууж байна гээч: наад маягтад чинь нөхрийн чинь тухай, түүний эцэг эх, өвөө эмээгийн тухай олон асуулт бий, тэднийг бөглөхөд тун ярвигтай, олон зүйлийг та хоёрын хэн нь ч мэдэхгүй байж болно, тэгвэл ийш тийш нь бичиж асууж лавлах хэрэг гарна...

Харин та хоёр бүртгүүлээгүй, бас хүүхэд байхгүй бол гэр бүлийнхээ байдлыг бичихгүй, тэр тоо томшгүй олон асуултыг бөглөхгүй байж болно.

Варя энэ юу гэсэн үг болохыг тэр даруйдаа сайн ойлгож чадахгүй чимээгүй суузнав. Бодвол үүний цаана ямар нэгэн хоёрдмол санаа байхгүй, үнэнээсээ ярьж байгаа байх. Гэхдээ доромжлох зүгийн аль нэг юм байх шиг. Гар үйлдвэрчин, хувийн өмчтөний алин болох нь бүү мэд, нэг үгээр хэлбэл чухам хэн нь мэдэгдэхгүй нэг бильярдчинтай суусан гэх мэтээр Вика л элдвийг бураа биз. Тэгээд л түүнийг ажилд авах асуудал яршигтай болох вий гэж Игорь Владимирович болгоомжилж байна. Өө, үхсэн хойшоогоо! Үгүй ердөө! Өөр газар ажилд орж болох юм чинь. Ийм мундаг биш, ийм маягт шаардлагагүй газар.

Игорь Владимирович түүний бодлыг яг тааж,

–Өөрийнхөө зөв гэж бодсоноор л болоорой. Бид таныг ямар ч нөхцөлд ажилд авахдаа л авна. Би зүгээр л таныг энэ лайтай шал хэрэггүй дэмий ажлаас хөнгөлж өгөх л гэж тэгсэн юм гэв.

–Би үзье ээ гэж Варя тогтуухан хариулав.

–Энэ маягтыг баллаж сохолбол дахиад бөглүүлж чадах улс шүү, тийм учраас эхлээд зүгээр цаасан дээр хариултаа бичиж сайн шалгаж магадлаад дараа нь маягтдаа хуулж бичсэн нь дээр гэж зөвлөмөөр байна.

–За, би яг тэгнэ ээ.

–За маш сайн байна хэмээн Игорь Владимирович босох зуур өгүүлж, — Маргааш таныг хүлээж байя. Бид нар есөд эхлээд дөрөвт тардаг юм. Бидэнтэй ажиллахад танд аятайхан байх болов уу гэж найдаж байна гэв.

Варя явган харихаар Их сургуулийн дэргэдүүр гарч дараа нь Воздвиженкаар өгсөж Арбат руу оров.

Игорь Владимировичтай маягтын тухай ярьснаас үүссэн эвгүй булинггар жинхэнэ амьдралыг

шүргэсэндээ хөөрч баярласан сэтгэлд сэв суулгахгүй байж чадсангүй. Лёвочка, Рина хоёр ёстой сайн байна! Тэдний хувьд ресторан, Эрмитаж цэцэрлэг энэ тэр бол хоёрдугаар зэргийн зүйл, гол юм нь Москвагийн төвийн нүсэр том барилга байгууламжийн холбогдолтой ажил. Зургийн самбар, чигтэй шугам, жирийн шугам, лекал, зургийн үзэг, хурц үзүүрлэсэн харандаа, бас бэхний үнэр сэлт Варяд төрөлх сургууль, шугам зургийн хичээл энэ тэрийг санагдуулжээ. Тэрээр шугам зургийн хичээлийг хэзээ ч тасалдаггүй сэн. Энэ бүхэн шинэ, сонин амьдралыг зөгнөн байх авай.

Игорь Владимировичийн тухай гэвэл Варягийн санаа зовсон нь талаар хэрэг байж тэрээр энэ хүний өмнө ямар ч буруугүй, харин ч болбоос тэр нэгэн удаа Вика тэр хоёртой “Канатик” яваагүй нь шударга явдал болсон билээ. Игорь Владимирович Вика шиг хийсвэр амьдралтай хүн биш гэдэг нь тэгэхэд л ойлгогдож байсан болохоор түүний толгойг эргүүлж зүрхлээгүй. Түүнээс гадна мань хүн тэр үед хөгшин юм шиг санагдсан. Гэтэл Костягийн л үе тэнгийн хүн юм шиг байна шүү дээ.

Нөхрийгөө маягтад бичихгүй байхыг зөвлөж байгаа нь Варяг намтраа бүү будлиулаг гэж санасан хэрэг биз. Алдартай уран барилгач байж айж хулчийж байх юм. Харин өөрөө бол хэнээс ч айхгүй. Костя ямар ч хүн байлаа гэсэн өөрөө түүнийг нуух бодол алга. Өөрийнх нь нөхөр, тэдний төрөл төрөгсөд тэдэнд ямар пад байна, ямар тэд нар ажилд орох гэж байгаа биш, өөрөө л орох гэж байгаа юм чинь, өөрийг нь шалгавал барав биз.

Варя гэртээ ирсний дараа ширээний ард тухлан суугаад маягтыг дэлгэж гүйлгэн харлаа.

Маягт нь дөрөв биш найман нүүртэй аж. Асуултуудыг үзээд эхлээд гайхширч, дараа нь зэвүүрхэн уурсаж, эцэст нь бүр нэгмөсөн арга барагдав.

Игорь Владимировичийн зөвлөсний дагуу дэргэдээ ноорог хийх цаас тавиад хариултаа түүн дээрээ эхлэн бичиж гарав.

1. “Овог, нэр. Өөрчилсөн бол түрүүн ямар овог буюу нэртэй явснаа бичнэ үү”. За, энэ ч тодорхой байна. Иванова Варвара Сергеевна, овгоо өөрчилж яваагүй.

2. “Төрсөн он, сар, өдөр, газар”. Бас тодорхой зүйл: 1917 оны дөрөвдүгээр сарын 5, Москва.

3. “Яс үндэс, харьяалал (өөр улсын харьяат байсан бол бичнэ үү)”. Бас тодорхой зүйл: орос, ЗСБНХУ-ын харьяат.

4. “Угсаа язгуур буюу хувьсгалын өмнөх нийгмийн гарал (тариачин, хотынхон, худалдаачин, язгууртан, хүндэт иргэд, санваартан, цэргийнхэн гэх мэт алин болох)”. Эцэг эх нь багш байсан юм чинь энэ бол ямар язгуур байх вэ дээ? Нинагаас асуух хэрэгтэй юм. Ингэхэд эцэг эх нь санваартан бол “ламын охин”, эсвэл цэргийн хүмүүс бол “офицерын жаал” гэхчлэн тийм хүүхдүүд хөөрхий еэ.

5. “Боловсрол”. Энэ ч амархан зүйл: шугам зураг зохион бүтээх чиглэлтэй дунд сургууль төгссөн.

6. “Ямар ямар гадаад хэл мэдэх вэ?”. Хариулт: германаар ойр зуурхан ойлголцоно.
7. “Намын гишүүн эсэх, намд байгаа хугацаа”. Нам бус.
8. “БХЛКЗЭ-д элссэн хугацаа”. БХЛКЗЭ-д элсэж байгаагүй.
9. “БХК(б)Н буюу БХЛКЗЭ-д түрүүн байсан бол ямар хугацаанд байсан, яагаад гарсан шалтгаанаа бичнэ үү. Өөр намд гишүүн байсан уу?” Варя БХК(б)Н, БХЛКЗЭ-ийн алинд ч, бас өөр ямар ч намд гишүүн байгаагүй гэж бичив.
10. “БХК(б)Н буюу БХЛКЗЭ-д байх хугацаанд арга хэмжээ авагдсан эсэх(хаана, хэзээ, хэнээр, ямар, юуны, учир, мөн түүнийг арилгасан эсэх, арилгасан бол хэн)”. Хариулт: юуны ч гишүүн байгаагүй болохоор ямар ч арга хэмжээ авагдаж яваагүй, арга хэмжээ авагдаагүй учир арилгасан зүйл байхгүй.
11. “БХК(б)Н-ын чиг шугамыг хэрэгжүүлэхэд гуйвж байсан эсэх, эсрэг хүчний эвлэл, намын эсрэг бүлэглэлд оролцож байсан эсэх (хэзээ, хаана, ямар)”. Энд ингэж хариулна: БХК(б)Н-ын гишүүн байгаагүй учраас чиг шугамыг нь хаа ч хэрэгжүүлж байгаагүй, тийм болохоор гуйвж яваагүй, эсрэг хүчний эвлэл, намын эсрэг бүлэглэлд оролцож байгаагүй.
12. “Та буюу таны төрөл төрөгсөд мөрдөгдөж, шүүхэд татагдаж байсан эсэх, баривчлагдаж шүүх буюу захиргааны шугамаар ял шийтгэгдэж байсан эсэх, сонгуулийн эрхээ хасагдаж байсан эсэх, одоо мөрдөгдөж буюу шүүгдэж байгаа эсэх, мөн ял эдэлж байгаа эсэх”.

Варяд шорон, мөрдлөг, шүүхийн аль нэгэнд байгаа хүн байхгүй. Ер нь Козловт байдаг хамаатан эгчээс нь өөр төрөл садан ч гэж байхгүй, харин энэ эгчийнхний хэн нэгийг шоронд хийчихсэн юм уу сонгох эрхийг нь хасчихсан юм биш байгаа? Өөрөө ч “байхгүй” л гээд биччихнэ л дээ, гэхдээ ямар нэг юм нууж, нөгөө ид шидтэй боловсон хүчнийх нь хэлтэс өөрийнх нь мэдэх битгий хэл зүүдлээ ч үгүй нэг баригдсан садангийнх нь хүнийг нэрлэж мэдмээр санагдаад байв. Софья Александровна ажилд орохдоо ийм маягт бөглөсөн гэж үү дээ? Тэгээд Сашагийн тухай бичихэд хүрсэн гэж үү?

13. “Гадаадад байсан эсэх, ямар оронд, хэдийнээс хэдий хүртэл, юу хийж байсан...”
Байгаагүй.

14. “Таны болон таны гэргийн (нөхрийн) төрөл садангийн хүн гадаадад одоо байгаа эсэх, эсвэл урьд хожид байсан эсэх (хэн, хаана). Тэдэнтэй холбоотой (урд нь холбоотой байсан) эсэх, таны садангийнхнаас хэн нэгэн хүн гадаадын харьяат байсан эсэхийг бичнэ үү?”.

Тэдний сургуульд Арбатын хөндлөн гудамнуудын хуучин язгууртан агсан олон хүний хүүхэд суралцдаг байсан, тэд нарт бол бүгдэд нь гадаадад хамаатнууд байгаа, Пушкин, Толстой эд нарын олон ач үрс гадаадад бий. Тэгэхлээр тэр хөөрхий амьтад энэ асуултад яаж хариулдаг бол? “Хаа” байгааг нь бичих хэрэгтэй юм байна, гэтэл гадаадынхантай захидлаар харилцахаас бүгдээрээ айцгаадаг юм чинь “хаа” байгааг нь хэн мэдэх билээ.

15. Та болон таны садангийнхнаас империалист буюу иргэний дайны үед олзлогдох буюу

баригдаж эрх чөлөөгөө хасагдаж байсан эсэх”. За ингээд империалист дайнд хүрчихдэг юм байна!

16. 17, 18, 19, 20, 21. Улаан Арми, партизан, нууц бүлгэмд байсан эсэх, шархадсан, бэртсэн байдал. Цөмөөрөө -үгүй!

22. “Төрөл садангийнхнаас (27-д тоочсон) хэн хэн өөр намын гишүүн байсан, хэн хэн хувьсгалын өмнө цагдаа, прокурорын газар, шүүх, шоронгийн захиргаа, хилийн буюу хуягийн хамгаалалтад ажиллаж байсан”.

За, 27-д хэнийг дурдах ёстойг харъя. “Эхнэр, нөхөр, хүүхэд, эх, эцэг, ах, эгч, дүү нар. Нөхөр нь өөрийнхөө болон эхнэрийнхээ бүх төрөл төрөгсдийг бичнэ, эхнэр нь өөрийнхөө болон нөхрийнхөө бүх төрөл төрөгсдийг бичнэ...” Ээ, бурхан минь! Тэгвэл зөвхөн өөрийнхөө бүх хамаатныг бичээд зогсохгүй Костягийн бүх төрөл төрөгсдийг бичих ёстой болох нь, тэд нар хувьсгалаас өмнө хилийн буюу хуягийн хамгаалалтад алба хааж байсан эсэхийг бичих нь. Костя өөрөө энэ тухай мэддэг юм болов уу? Хүн яахаараа нөхөр буюу эхнэрийнхээ төрөл садангийнхны төлөөнөөс хариулж байх ёстой юм бэ?

23. “Гэр бүлийн байдал (эхнэртэй, эхнэргүй, бэлэвсэн), гэр бүлийн гишүүдээ тоочиж, тэдний насыг бичнэ үү. Хэрэв бэлэвсэн, салсан буюу хоёр дахиад гэрлэсэн бол өмнөх эхнэрийнхээ (нөхрийнхөө) овог, нэрийг бичнэ үү?..” Үгүй, энэ зураг төслийн товчоонд хорин жилийн өмнө нас барсан эхнэр ямар пад байна аа? Зочид буудлын төсөлд энэ ямар хамаатай байж болох вэ?

24. “Одоогийн хаяг”. Ойлгомжтой...

25. “Төрсөн өдрөөс эхлэн гэрийн бүх хуучин хаяг...” Өөрийнх нь хувьд тодорхой. Арбатын энэ байшингаас өөр хаа ч амьдарч яваагүй. Гэтэл энэ маягтыг ахимаг насны хүн бөглөж байгаа бол хичнээн хаяг санаж байх ёстой байх нь вэ? Зүгээр ч үгүй, төрсөн өдрөөсөө хойш шүү! Хэрэв заяа эцэг эх нь нас барсан бол хүн яаж хүүхэд ахуйнхаа хаягийг мэдэх билээ?

26. За, нөгөө Игорь Владимировичийн анхааруулж байсан хамгийн мапаантай асуулт: “Таны ойрын садан төрлийнхний тухай мэдэгдэхүүн (эхнэр, хүүхэд, эх, эцэг, эх, эгч, дүү нарынхаа тухай бичнэ үү. Эхнэр нь өөрийнхөө маягтад нөхрийнхөө тухай, мөн өөрийнхөө ойрын садан төрлийн тухай бичнэ). Овог, нэр, төрлийн ямар холбоотой, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, яс үндэс, намын гишүүн эсэх, ажлын газрын нэр, хаяг, албан тушаал, оршин суугаа газрын хаяг. Эхнэр, нөхрийн төрөл садангийнхны тухай мөн эдгээр мэдэгдэхүүн”. Тэгэхлээр энэ бүх мэдэгдэхүүнийг зөвхөн Нина, талийгаач аав ээжийн тухай төдийгүй Костягийн бүх төрөл төрөгсдийн тухай бөглөх ёстой болох нь. Гэтэл тэр чинь таван ах дүүтэй, хоёр эгчтэй, тэд нь Зөвлөлтөөр нэг тарчихсан байгаа, эцэг эх хоёр нь бол бүр хөрөнгөө хураалгасан нударганчууд.

Игорь Владимирович зөвхөн сайныг хүссэндээ л нөгөө нэг зүйлийг анхааруулж байсныг Варя одоо ойлгож эхлэв. Гэхдээ мань хүн тэгж эвлэрэхгүй, тэгж юмны аяг дагахгүй, тэгдэг хүн харахан биш!

За яахав, энд өөр юу байна?

“Шинж: чац, үс, нүд, бусад шинж”.

Зөвхөн хурууны хээ л дугаж байх шив. Үгүй, энэ ч арай дэндэж байна шүү! Больж үзье, чи минь! Энэ доромжилсон байцаалтад хариулж байдаг нь би биш. Ийм маягт бөглөх шаардлагагүй газар олно, ердийн зураг төслийн газарт зураг хордуулан буулгагч бас л хэрэгтэй шүү дээ. Аргаа барвал ерөөсөө ажилд орохгүй, дээд сургуульд орох бэлтгэл хийнэ, тэгж байгаад хойтон Уран барилгын дээд сургуульд өргөдөл өгнө. Оюутны цалин өгөхгүй байсан ч хамаагүй. Костяд “Надад үнэтэй цайтай юм битгий авч бай, тэр мөнгөөр чинь би сургуульд суралцъя” гэж хэлнэ. Саяхан өөрт нь бэлэглэсэн хар үнэгэн нөмрөг бодвол оюутны хоёр гурван жилийн цалинтай тэнцэх үнэтэй байлгүй. Бас муусайн хувцас хунараа зарах юм бол хэдэн жил хүрэлцэх мөнгөтэй болно. Юмаа зарсан ч гэсэн оюутан болж ном үзнэ, толгой түрийгүй, өөд уруугүй шалгах явдал үгүй болно. Тэгээд дипломтой уран барилгач болсон цагт ийм маягт бөглүүлэх гэж чичилж зүрхлэх хүн гарахгүй.

Варя маягтыг эвхэж ширээн дээр хаяв. Маргааш Костяд үзүүлж жаал инээлгэх юм шүү.

Тэрээр гэрийнхээ халаадыг өмсөөд даашинзаа босоо шүүгээндээ өлгөв. Тэгээд шүүгээнийхээ хаалгыг хааж байтал дотор нь юм дугаж байх шиг гэнэтхэн санагджээ. Нээрэн, тийм байна! Саяхан Костягийн бэлэглэсэн нөгөө хар үнэгэн нөмрөг нь алга. Зургаа юм уу найман үнэгний арьсаар хийсэн тэр нөмрөг ёстой их үнэтэй эд. Варя Старо-Пимений гудамд очихдоо л түүнийгээ цорын ганцхан удаа нөмөрсөн билээ.

Варя шүүгээн дотроос даашинз, пальто, хантаазаа гарган сэгсчиж баахан онгичсон боловч нөмрөг нь байдаггүй. Хөндөж сандаасан юм ер байхгүй хэрнээ зөвхөн нөмрөг л алга. Варягийн толгойд хамгийн түрүүнд хөрш хүүхэн Галя орж ирэв. Эсвэл түүний хүү Петька гэдэг арван тавтай гудамжны дэггүй банди.

Софья Александровна ажлаасаа хэдийн ирсэн байсан тул Варя тэдний өрөө рүү тогшиж ороод хаалгыг нь сайтар татаж хаав.

–Софья Александровна, миний хар үнэгэн нөмрөг алга болчихож.

–Юуны чинь алга болчихож гэж? хэмээн Софья Александровна мэгдэн сандрав.

–Өглөөхөн л шүүгээнд өлгөөтэй байсан юм, гэтэл одоо алга.

–Чи сайн эрэв үү?

–Шүүгээгээ хуу онгичлоо. Хулгай авчихжээ!

–Хулгайлах ий? Хэн тэр вэ?

–Хэний нь бүү мэд. Галя юм уу тэдний хүү байж магадгүй.

–Үгүй, тэдэнд чинь танай өрөөний түлхүүр байхгүй шүү дээ... Би тэдэнтэй энэ байранд олон жил аж төрж байна. Хэзээ ч тийм явдал болж байгаагүй.

–Түрүүхэнтэйгээ Петька жаахан байсан л даа, одоо торниод хулгай хийдэг болсон хэрэг, хүн гайхаад байх юм алга.

–Сэргийлэхэд утасдаж мэдэгдэх хэрэгтэй гэж Софья Александровна хэлэв.

Гэвч Варя Костягийн эзгүйд сэргийлэх рүү утасдмааргүй байв. Яагаад тэр вэ? Яагаад гэдгээ өөрөө ч эс мэднэ. Гэвч эхлээд Костяд хэлж байж дараа нь сэргийлэхэд мэдэгдэх хэрэгтэй гэж бодогдоод байв.

–Костяг хүлээх хэрэгтэй.

–Юу гэсэн үг вэ, Варенька минь! Константин Фёдорович оройтож ирнэ. Сэргийлэхэд чинь тэр дор нь мэдэгдэх ёстой. Эс тэгвэл тэд чинь дараа нь яагаад тэр дор нь мэдэгдээгүй вэ? гэнэ.

–Би шүүгээгээ хэзээ онгойлгосныг тэд хаанаас мэдэх вэ дээ. Маргааш очоод л тун сая онгойлгож үзээд юм алга болчихсоныг мэдлээ гээд хэлчихнэ.

–Маргааш болчихлоор тэд нарт эрж хайхад улам хэцүү болно хэмээн Софья Александровна өөрийнхөөрөө зүтгэж, — Хойш нь тавилгүй яг халуун мөрөөр нь хайх хэрэгтэй. Энэ ч тун эвгүй л дээ, би ойлгож байна, гэхдээ өөр арга алга шүү дээ. Тэр нөмрөг чинь бүхэл бүтэн хөрөнгөтэй дүйх үнэтэй эд. Тэгээд ч хэрвээ Петька хулгайлсан бол бүр зүгээр өнгөрөөж болохгүй, эс тэгвэл цаашдаа бидний юмыг хумслаад байх болно. Тэгвэл амьдрал маань юу болж хувирахсан билээ! гэв.

–Би одоо Костяг хайж олоод түүнтэй зөвлөө гэж Варя хэлэв.

Тэгээд хувцсаа сольж цуваа нөмрөөд гарлаа.

Сэргийлэхэд утасдахаас юунд нь цааргалав, юунаас болгоомжлов, яагаад Костя руу гүйх болов? Санхүүгийн байцаагчаас болсон юм болов уу? Тэд Костягийн эд хөрөнгийг бүртгэж авсан юм чинь. Сэргийлэхийнхэн тийм үнэтэй нөмрөг хаанаас авсныг сонирхож болзошгүй, тэгэхлээр Костя бэлэглэсэн гэдгийг хэлэх ёстой болно, тэгвэл... Юу тэгвэл гэж? Тэгвэл гээд юу гэх гэснээ өөрөө ч эс мэднэ. Ямар ч атугай Костяд хэлэлгүйгээр сэргийлэхэд мэдэгдэж болохгүй гэдгийг тов тод ухамсарлаж байв. Мань хүн тэр нөмрөг хаанаас гарч ирснийг ч чухамдаа мэдэхгүй билээ. Костя авчирч задлаад л,

–Нөмрөөд үз! гэсэн юм. Нөмрөг тун сайхан таарсан.

–Чамд бэлэг болгож байгаа юм.

–Баярлалаа. Ямар өртөгтэй юм бэ?

–Чамд ямар ялгаа байна? Өртөгтэй эд. Хямд биш. Шинэ нөмрөг байсан юм чинь дамаас авсан байх, эсвэл ямар нэг нууц оёдолчин оёсон юм уу, торгоны дэлгүүрээс авсан ч байж магадгүй. Ямар ч байтлаа гэсэн хулгайлсан зүйл биш, хулгайн юм байсан бол Костя юу гэж тэр нөмрөгийг өмсүүлээд жүжигчдийн клубт дагуулж очих вэ дээ. Тэгсэн хэрнээ хаанаас

худалдаж авснаа огт хэлээгүй. Костятай холбоотой ямар ч юм байсан дандаа түүнийг хөөдөж мэдэх бас нэг талтай билээ.

Тэрээр Костяг “Метрополийн” бильярддын тэндээс олов. Бильярд бол эмэгтэй хүн байх газар биш, Варя ийм газар ирэх үнэн голоосоо дургүй. Зөвхөн эрчүүд цуглана. Эрүүл, халамцуу, согтуу эрчууд түүнийг нөхрөө эндээс салгаж авах гэж ирсэн, нойтон хамуу шиг амьтан үзсэн мэт зарим нь сониуч, зарим нь дооглосон янзаар харах ажээ. Тамхины утаа суунаглан бүгчим гэдэг нь жигтэйхэн. Цонхир цонхир царай, найгүй найгүй архичин...

Костя Варяг анзаарсангүй бильярддын бөмбөлөг, оруулах нүх, цохих мод гурваасаа өөр юу ч харахгүй байгаа бололтой, нөгөө тоглогчийнхоо цохихоос хараа салгахгүй, тэмдэглэх самбар дээр нэг юм бичсэнээ тэр дорхноо ширээ рүү эргэж ирэх нь тоглоомдоо хорхой нь асаж мэрийж улайсан нь илт.

Энэ тоглолтыг хэн нь хожсоныг Варя ойлгосонгүй. Костя шүүгчид нэг юм хэлэхэд цаадах нь бөмбөлгийг шинээр гурвалжлан тавьж байна. Костя цохиураа дахин шохойдох зуур сая бильярддын өрөөг болгоомжтой хурц харцаар эргүүлдэн харахдаа үүдэнд зогсож буй Варяг үзэв. Түүнийг ирнэ гэж хүлээж байсан юм уу гэлтэй огт гайхаж хачирхсангүй, гагцхүү хөмсгөө зангидсаар цохиураа барьсан чигээрээ дөхөж ирэв.

–Гарцгаая!

Тэр хоёр бильярддын үүдний бяцхан тасалгаа руу гарав. Тэнд хоёр жижгэвтэр буйдан, нэг олмогт сандал байв. Тамхиа энд л татах ёстой байлгүй гэж Варяд бодогдов. Тэрээр Костягийн царайг хараад сэргийлэх рүү утасдах хэрэггүй юм байна... гэдгийг ойлгож гэнэтхэн тайвширлаа.

–Юу гэж яваа юм бэ? хэмээн Костя Варя руу харалгүй асуув.

–Нөмрөг алга болчихжээ.

–Ямар нөмрөг?

–Нөгөө хар үнэгэн нөмрөг, чиний надад бэлэглэсэн.

Костя түүний юу ярьж байгааг огт ойлгохгүй байгаа юм шиг хэдэн хором зөрүү харж дуугүй зогсов. Варя энэ хоромд огт танихгүй хүн дэргэд нь зогсож байна гэж боджээ.

Тэгтэл цаадах нь,

–Би чамд өөр бүр сайн нөмрөг авч өгнө. Би хожигдчихоод мөнгө олж чадалгүй чиний нөмрөгөөр тооцоо хийхээс өөр аргагүй болсон, эс тэгвэл тэд намайг алах байсан юм. Гэртээ харь, би ч бас удахгүй очно гэв.

Варя гэртээ буцаж ирэв.

–За яав? гэж Софья Александровна асуув.

–Константин Фёдорович нөгөө нөмрөгийг чинь оёдолчинд янзлуулах гээд аваачаад өгчихжээ. Сэргийлэх рүү утасдаагүй маань л сайн юм боллоо.

Варя өрөө рүүгээ орж цуваа тайлж өндөр өсгийтөө мулталж хаяад буйдан дээр лагхийн сууж бодолд автав.

За ингээд нөмрөгийг мөрийд алдчихсан байх нь. Бас хаанаас олсон нь мэдэгдэхгүй байгаа. Магадгүй яг тийм нэгэн мөрийчнөөс хожсон, цаадах нь авгайнхаа нөмрөгийг тийнхүү алдчихсан байж ч мэднэ.

Варяд тэр нөмрөг хайран биш л дээ, тэр муу яахав! Гэхдээ өнөөдөр нөмрөг, маргааш пальто, нөгөөдөр шаахай. Архичин хүн авгайнхаа юмыг уучихдаг, тоглоомчин мөрийд алдчихдаг юм байна. Вика, Ноэми, Нина Шереметева энэ тэр завхай хүүхнүүд, гэвч тэд нар өөрснийхөө хувцсыг бусдын мөрөнд углаатай байхыг үзэх вий гэж санаа зовох юмгүй улс. Өнөөдөр өөрийнх нь хувцас хунарыг мөрийд алдаж байгаа юм чинь маргааш түүнийг өөрийг нь мөрийд өгчихөж мэднэ. Өөрөө өдий болтол яасан тэнэг хүүхэн яваа вэ! Худлаа биеэ даасан байдалд нь хууртжээ. Одоо тэр биеэ даасан байдлын үнэ цэнийг мэдлээ. Варя одоо бильярддын ширээн дээр бөмбөлөг яаж өнхрөхөөс хамаарах хүн болсон хэрэг.

Ийм хувь заяанд тэрээр хорхойтохгүй, Костягаас хамаарч байж чадахгүй, хүсэх ч үгүй, өгчихөөд дараа нь мөрийд алдчихдаг бэлэг хэрэггүй, түүний тусламжтайгаар дээд сургуульд орж төгсөхгүй. Гагцхүү өөрийнхөө хүчинд л найдах хэрэгтэй. Нөгөөдөх маягт яахав дээ! Хаа л бол маягт, хаа л бол ийм ёстой юм чинь. Танихгүй хөндлөнгийн хүмүүсийн дунд тийм юм бичиж байснаас найз нөхөд нь байгаа газар тэр маягтыг бөглөөд орсон нь дээр. Игорь Владимирович зүйтэй юм зөвлөжээ. Костягийн тухай юу ч бичихгүй, өөрийнхөө тухай бичиж байгаа нь их юм. Ер нь Костягийн тухай яах гэж бичих билээ? Одоо бүх юм тодорхой боллоо. Тэр хоёрын гэр бул хэврэгхэн, тохиолдлын зүйл гэсэн совин байнга татаад байсан шүү дээ.

Харин өөрийнхөө тухай бичихэд тун амархан. Аливаа яршигтай асуултад “үгүй!” гэдэг ганцхан хариулт бий. Талийгаач эцэг эхийнхээ тухайд бол Нинкагаас асуух хэрэг болох нь, Нинка бүх юмыг мэдэж байгаа.

Үнэнийг хэлэхэд Нинка Костягаас болоод өөрийг нь тоохгүй, гэрээр нь орж гарах, утасдах нь битгий хэл хашаан дотор тааралдахад янзгүй толгой дохиж мэндлэхээс цаашгүй байгаа билээ. Дураараа болог! Харин эцэг эхийн тухай хэрэгтэй юмыг хэлж өгөх албатай, ямар ганцхан түүний эцэг эх биш дээ. Гэтэл Нина одоо гэртээ байгаа болов уу, үгүй болов уу?

Тэрээр утасдаж үзтэл Нина гэртээ байж байв.

–Би Варя байна, чам дээр одоо очлоо, надад нэг хэрэг байна.

–Хэрэг байгаа юм бол ир л дээ гэж Нина хайхрамжгүй өгүүлэв.

Шал дэмий утасдлаа. Зөвшөөрөл гуйсан юм шиг болчихсон байна. Зүгээр л яваад очдог байж.

Варя бүтэл муутайхан гэрлэсэн байх юм гэхэд Нина дүүгийнхээ хувь зохиолоос хуваалцаж, өмгөөлж хамгаалж, аялж тайтгаруулахсан билээ. Гэтэл энэ болсон явдал бол зүгээр нэг бүтэлгүй хэрэг биш эцэг эх нь амьд сэрүүндээ хичээнгүйлэн захидаг байсан, өөрснөө ч үнэмшин итгэж явсан нөгөө ариун нандин үзэл бодлоосоо урван тэрсэлсэн хэрэг мөн. Нэг удаа Юра Шарок Нинатай хашаан дотор тааралдахдаа,

–Танай Варя чинь хулгайчтай нөхөцчихжээ гэж хэлсэн юм.

Нина Шарокт дургүй. Гэвч Лена Будягина дахиад түүнтэй нийлсэн учир тэр хүүхнийг бодоод Шароктой муудалцахыг хүсээгүй ажээ. Тэглээ ч гэсэн Юркагаар заалгахдаа хүрэхгүй хэмээн,

–Хулгайч яагаад сул явж байдаг юм бэ? гэж өчжээ.

–Цагаа болохоор сууна даа гэж Шарок амлах мэт хэлэв.

Юра үнэн ч хэлсэн бай, худлаа ч хэлсэн бай, энэ Варягийн хар хүн шүү этгээд бол Нинагийн үнэн голоосоо үзэн яддаг нөгөө ресторан, мөрийчид, дамчид, луйварчдын ертөнцөд хамаарах үнэхээр эргэлцээтэй хүн. Ингээд л Варя, Нина хоёр салаа замаар оржээ. Софья Александровна түүнийг гэртээ хоргодуулж байгаа нь ч санамсаргүй хэрэг биш, тэрээр Сашаг цөлсний учир Зөвлөлт засгийг уучилж чадахгүй байгаа болохоор бас л өөр талд байгаа хүн. Гэхдээ Сашаг цөлсөн нь алдаа юм гэж санахад Зөвлөлт засаг үүнд ямар ч хамаа байхгүй, аль ч засаг алдаа хийхгүй гэсэн хууль байхгүй. Тэгэх тусмаа улс оронд ангийн хатуу ширүүн тэмцэл явж нам аливаа дайсагнасан нам, бүлэг, эсрэг үлдэгдлийг устгахаас өөр юмгүй байхад ганц нэг алдаа гарах нь зайлшгүй.

Харин Сашад тохиолдсон явдлын тухайд гэвэл ямар юмных нь алдаа байх вэ дээ! Сашагийн сурч байсан сургуульд зөвлөлтийн эсрэг байгууллага байсан, тэд нар Сашаг ашигласан, гэтэл мань хүн тэднийгээ хамгаалж байгаад цуг баривчлагдсан гэж Лена Будягина Юра Шарокийг хэлсэн хэмээн Нинад ихэд дотночлон нууцгайлж шивэглэсэн билээ. Харин ч түүнийг толгойлогч биш гэдгийг илрүүлсэн учраас гуравхан жил цөлөх ял заасан, түүнд хариуцлага хүлээлгэлгүй яах вэ дээ, мань нөхөр мундаг нагац ахтай гэж Рязановт найдаад мөрдлөгийн үед дутагдлаа хүлээхгүй их хэдэр давилуун байсан гэх маягийн юм Шарок битүүхэн хэлсэн ажээ. Гэхдээ Рязановын хөөцөлдлөг Иван Григорьевич Будягиныхтай нэг адил ямар ч нэмэр болоогүй юм.

Софья Александровна эвлэрвэл зохих юм, ямар хүүхэд биш том хүн чинь ойлгох ёстой шүү дээ. Гэтэл мань авгай бүх хүнийг үзэн ядаж, бусдыг ч гэсэн адилхан муу явуулах санаатай, Варяг тэр луйварчинтай нь хамт өөрийндөө орогноулснаар Нинаг төдийгүй Сашагийн бүх найз нарыг өдөж байгаа нь тэр.

Гэхдээ шударгаар хэлэх юм бол Варя ч энэ замыг бүр сургуульд байхаасаа сонгож авсан хүн л дээ. Банди нар, уруулын будаг, элдэв новшоор хөөцөлдөөд л. Нина түүнийг тэр үед нь ч яаж ч чадаагүй, одоо ч яаж ч чадахгүй байна. Тэгэхлээр, төөрөг нь л мэдэхээс! Одоо юу ч тохиолдсон өөрөө л учрыг нь олно биз. Тэр муу нөхөр шүү юмандаа энд суух зөвшөөрөл авна

гэж горьдсоны гарз, манайх яг хоёрхон хүний зайтай. Хулгайч, луйварчин, мөрийний бильярдчинд орон сууцнаасаа хумсын чинээ ч өргөл барихгүй. Яаж л амьдардаг санж, хаана л амьдардаг санж өөрсдөө мэдэж. Варя, мэдээжийн хэрэг, одоо орон сууцны талаар морилж ирэх гэж байгаа л даа.

Гэвч Варя шал өөр асуудлаар иржээ. Маягт бөглөхөд шаардагдах мэдэгдэхүүн хэрэгтэй гэнэ, тэр маягт нь ажилд ороход хэрэгтэй юм гэнэ.

Варя ажилд орох хэрэг үү?! Санамсаргүй юм байна! Хачин юм даа! Одоогийнх нь аж төрж байгаа байдалтай нэг л уялдаж авцалдахгүй санагдана.

–Хэрэв нууц биш бол хэлчих, чи чинь хаана ажилд орох нь вэ?

–Нууц байхгүй ээ. “Москва” зочид буудлын зураг төсөл хийх товчоонд.

Сайн сайхан яваагаас болж ингээгүй, тэр нөхөр шүү юмных нь хэрэг явдал бүтэл муутай болоод л энэ гэдгийг Нина бүрэн ойлгов. Гэвч асууж шалгаасангүй. Хэрэгтэй бол өөрөө л ярина биз.

–Чамд ямар мэдэгдэхүүн хэрэгтэй юм бэ? Варя маягтаа өгч 27-дугаар зүйлийг заав: “Таны ойрын төрөл садангийн тухай мэдэгдэхүүн...”.

–Чи надад цаасан дээр бичээд аль, би дараа нь маягтдаа хуулаад биччихнэ.

Тэрээр сууж өрөөг эргэн тойрон харав.

Ханан дээр өлгөөтэй буй Максим Костины зургаас өөр шинэ юм юу ч алга. Захныхаа түдүүл дээр цолын дөрвөлжин тэмдэгнүүдтэй цэрэг цамцтай, энгийн дөлгөөн сайхан царайтай зураг ажээ. Ингэхлээр Нина Макстай захидлаар харилцдаг байх нь. Түүнтэй суучихвал барав биз дээ, энэ хоёр бие биедээ таарч байгаа юм чинь. Яваандаа цэргийн даргын авгай ээж хүүхэн болохгүй юу, энүүнд бас л зохих зүйл.

Өрөөний бусад юм цөм хуучнаараа. Номын тавиур дээр хүүхдийн нэвтэрхий толь бичгийн дэргэд гуутай зураг байгаа нь аав ээжийнх нь залуугийн зураг; цоохортож хуурсан хулдаасаар бүтээсэн ширээ; Нинагийн орон доогуурх налчийтал гишгэсэн гэрийн шаахай; харин Варягийн өөрийнх нь орон дээр хурц өнгийн алчуураар бүтээсэн дэр, орны дэргэд сунгасан чийрэг гартаа чийдэн барьсан тамирчны хүрэл цутгамал байна. Варя Софья Александровнагийн очихдоо гэрээсээ орныхоо цагаан хэрэглэлийг ч аваачаагүй, бас тэнд хэрэг болохгүй учраас эгшигт хайрцгаа ч аваагүй билээ. Хэдийгээр юм юм дутагдаж байгаа нь төдөлгүй мэдэгдсэн боловч тэрээр шинийг худалдаж авахаа урьтал болгожээ. Сургууль төгссөн гэрчилгээгээ авах гэж л ганцхан удаа гэрээрээ орсон, тэгэхэд Нинка гэртээ байгаагүй нь яамай.

Гэтэл одоо гэртээ орж ирээд, ганц умгар өрөөгөө, ижил дасал болсон эд юмсаа эргүүлдэн харж танил үнэрийг нь шимтэн амьсгалахуйд дахиад балчир нас нь эргэж ирэх мэт санагдаж уйтгар гуниг эзэмдэн авбаас хэдийгээр Нинка нь үглэж янцдаг ч гэсэн зөвхөн энд л амар

тайван байж чадах юм байна, энэ бол өөрийнх нь гэр, өөр оромж байхгүй, мөд бий болохгүй гэдгийг тодоос тод ухаарав. Нина бичсэн юмаа өгөв.

Варя түүнийг маягттай тулгаж үзвэл Нина бүх асуултад хариулж бүх юм ёсоор болжээ.

–За боллоо, баярлалаа... За, баяртай.

–Сайн яваарай.

Дүүтэйгээ зөв харьцав уу, яав? Үгүй, өөрөөр яаж харьцах юм билээ дээ? Баярласандаа харайж дэвхцэх уу? Варяг ажилд орох гэж байна гэж тэр уу? Бүх хүн ажил хийж байгаа. Тэгэх л ёстой юм чинь. Варя хэнийг ч гийгүүлээгүй. Дээд сургуульд орё гэсэн бол чадах л байсан байх. Гэвч хордуулан буулгагч хийх санаатай юм байж, хүн болгон өөр өөрийнхөө замыг сонгодог хойно яая гэхэв. Бид эмэгтэй хүний нэр төрийг ярьцгаагаад л байдаг хэрнээ эр хүний бараа харангуутаа түүнийгээ мартацгаах юм даа.

Варя ч бас яахав, гудамжаар хүмүүжсэн нэг муу охин... Гэтэл Лена Будягина даанч яав даа, ээ бурхан минь, тийм айлд өсөж бойжсон, нас бие гүйцсэн хүүхэн гэж байгаа шүү! Тэр өвөл Ленка Юрагаас хүүхэдтэй болчихоод нууцаар үр хөндөж золтой л үхээгүй (үүнийг Нина одоо мэдэх билээ), тэгэхэд тэр муу шившиг эмнэлэгт хүний урманд ганц удаа очоогүй, тэгээд хагас жилийн дараа үзэгдэхэд нь Ленка туунтэй зууралдчихсан байгаа юм даа. Тийм амьтан гэдгийг нь харахгүй байна гэж уу? ДЯАКГ-т зөвхөн жинхэнэ сайн чекистууд ажилладаг төдийгүй шургалж орсон этгээдүүд тэнд ч бас бий, тэдний нэг нь Юрка. Ленка үүнийг мэдэхгүй байх ёсгүй. Гэтэл дахиад шинэ түүх, шинэ “эмгэнэлт явдал” гарч. Нөгөө Юрка чинь бас өөр нэг юмтай толгой холбочихсон гэнэ. Тэгтэл Ленка тэр муу өчүүхэн хүний адгийг мартчихын оронд дахиад л зовж шаналж байх юм. Нина хүүхэн хүн эр хүний эрхэнд орчихдогийг үзэн яддаг агаад төрсөн дүү нь ийм болчихсоныг харсаар байгаа билээ. Ажилд орлоо гээд уг чанартаа өөрчлөгдөх юм байхгүй. Тэгэхлээр одоо хэр баярлах, бахдах юм ер алга.

Юра өөрийг нь араар нь тавьж байдгийг Лена цөхрөнгөө барсан нэг үедээ Нинад хэлжээ. Гэхдээ тодорхой юм юу ч тайлбарлалгүй “Тэр намайг араар тавьж байна” гэсэн цорын ганцхан өгүүлбэр хэлсэн ажээ.

Цаана нь тодорхойсоод байх элдэв юм байхгүй, ердөө Юра Вика Марасевичтай самуурч байгаа ганцхан тодорхой явдал байсан юмсанж. Тэр хоёр хүүхэн Маросейкад Старосадын хөндлөн гудмын нөгөө байшингийн шатны тавцан дээр улаан нүүрээрээ мөргөлдчихжээ. Ленаг цахилгаан шатнаас гарч ирэх мөчид өөрийнх нь орох гэж яваа байрны хаалгыг Вика дөнгөж хааж байв. Тэр хоёр хэдэн хором яах учраа олохгүй бие биеэ самгардан харсны эцэст Вика “Сайн уу” хэмээж, Лена хариуд нь мөн тийнхүү мэндлэх аяджээ. Тэгээд Вика хаагдаж амжаагүй байсан цахилгаан шат руу орж хаалгыг хаажээ.

Бушуухан зугтах бодол толгойд нь хамгийн түрүүнд орж ирж, Лена шат уруудан дараачийн давхар хүртэл гүйснээ амьсгаагаа даран чимээ чагнан зогтусав... Дор цахилгаан шатны хаалга дуугарав. Вика гараад явлаа гэсэн үг. Жаахан холдог... Лена дахиад нэг давхар алгуурхан доошлов... Ээ, бурхан минь! Ингээд бодоход нөгөө Шинэ жилийг тэмдэглэхэд болсон явдал

санаандгүй хэрэг биш, энэ хоёр хэзээнээсээ ийм яваа юм байна. Цөмөөрөнд нь энэ байдал илт байхад өөрөө л ганцаараа сохор юм шиг явжээ. Тэгээд л Нина түүнтэй хэрэлдэж Юрагийн нүүрэн дээр Саша өөрт нь “Чи энэ өөдгүй амьтнаас дээр юм олсонгүй гэж үү?” гэж асууж байж. Юра өөрийг нь ер хайрлаж хамгаалдаггүй байсан, одоо хүртэл гичний үнэр гарангуут дотор муухайрсаар байгаа. Эмнэлэгт байхад нь “Та ёстой золоор амьд гарсан шүү” гэж өөрт нь тэндхийнхэн хэлж байсан, гэтэл Юра хулчийж нуугдаад нэг ч удаа эргэж ирээгүй. Тэгсэн чинь өнөөдөр Викагийн тун сая сугарч боссон ор дэвсгэр дээр өөрийг нь хүлээж байсан байх нь.

Бодвол энэ ор дэвсгэрээр орж гардаг нь ганц тэр биш биз. Викатай яг нэг өдөр, бараг нэг цагт өөртэй нь болзоо товлохоосоо хүртэл айсангүй.

Лена яг ингэж бодмогцоо Юра таван цагт ирээрэй гэж гуйгаад байхад нь дөрвөн цагт хүрээд ирснээ сая ухаарав. Тэр тухай таг мартчихаад хуучин янзаараа дөрөвт хүрээд ирсэн ажээ. Тэр муу нэг цаг амардаг байх нь! Садар шулмас! Аягүй бол хоёуланг нь цуг өвөртөө ор гэж шаардах вий. Энүүнтэй ингээд гүйцээ, нэгмөсөн гүйцэх нь энэ! Яриа хөөрөө ч хэрэггүй. Түүний биеэ худлаа өмөөрөхийг сонсох дур алга.

Юра орой нь түүн рүү утасдаж өнөөдөр яагаад ирсэнгүй вэ? гэж тунирхсан дуугаар асуув.

–Ажил дээрээ саатаад.

–Мягмар гарагт ирж чадах уу?

–Чадахгүй.

–Тэгвэл хэзээ вэ?

–Мэдэхгүй. Чадвал өөрөө утасдана. Харин чи бол над руу дахиад битгий утасдаарай. Баяртай, Юра.

Энэ хүүхний юу нь болохоо байчихсан юм бол? Шарок учрыг олж ядав. Бух юм аятайхан л явж байх шиг байсан, тэр хоёр нэг их ойрхон уулздаггүй байсан нь үнэн, мань хүн тийм ажилтай юм чинь яах вэ дээ. Театр, кино, Жүжигчдийн клуб, үзэсгэлэн энэ тэрээр ханиндаа бишгүй л явсан... Юу гээд шил нь татчихаад байгаа юм бол? Хачин юм даа!

Ленагийн гоморхоод байгаагийн шалтгааныг Шарок тун удалгүй мэджээ.

Вика Ленатай мөргөлдөхдөө зөвхөн тэрхэн зуур л самгарджээ. Тэрээр Юра, Лена хоёрын харьцаа сэргэснийг Вадимаас дуулсан учир өөрийнх нь ийшээ ирдгээс шал өөр зорилгоор ирсэн гэдгийг Вика ойлгож байв. Юра өөрийг нь энд, энэ нууц байранд Ленад харуулдаг нь юу ч вэ? Өөрийг нь илчилчихлээ! Лена Юрагаас ямар учиртайг асууж шалгаах нь мэдээжийн хэрэг. Тэгэхлээр мань эр энэ байр бол зөвхөн амрагийн болзоонд зориулсан байр биш гэдгийг хүлээх болно. Гэтэл нууц ажилтныг илчлэх ёс байхгүй, тэгэхлээр мань хүн тэр хоёрыг харгалдуулсныхаа хариуцлагыг хүлээж таарна.

Ийм бодол толгойд нь оронгуут Вика тайвширч ямар шижим гарт нь орж ирснийг ухаарав. Одоо Юрочка өөрөө түүнийг суллаж тавихаас өөр аргагүй болно, одоо тэр муу заяа нь бултаж зайлж чадахгүй. Өнөөдөр өөрийг нь баахан доромжилсон, одоо тэр басамжилсан ярианыхаа шанг хүртэнэ ээ, гайгүй. Ийм яриа болсон ажээ.

–Юра, би хүнтэй сууж байгаа гэж Вика хэлжээ.

–Тийм үү? Хэнтэй тэр вэ? гэж Юра хөгжүүн асуужээ.

Вика Уран барилгачийн овог нэрийг хэлэв. Шарок энэ овог нэрийг мэдэх юмсанж. Гэхдээ гойд гайхаж байгаа царай харуулсангүй.

–Баяр хүргэе. Алдартай хүн шүү.

–Түүний төсөл Сталины сэтгэлд нийцсэн.

–Би тэр төслийг чинь үзэсгэлэн дээр үзсэн хэмээн Шарок Сталины өөрийнх нь биечлэн сайшаасан төслийн тухай өөрөө элдвийг ярьж яаж зүрхлэх билээ гэсэн шиг даруухан өгүүлэв.

–Юра, чи бид хоёр хагацах хэрэгтэй болох нь. Цаадах нь түүнийг ойлгоогүй дүр гаргаж,

–Ямар утгаар тэр билээ? гэв.

–Одоо би хүний авгай болсон, хэнийх гэдгийг нь чи мэдлээ. Миний амьдралын төрх өөрчлөгдөж ресторанаар хэсдэг явдал дуусаад, хуучин танилууд холбогдолгүй боллоо.

–Өөр хүмүүстэй л уулзана биз.

–Үгүй шүү, нөхөр маань явцуу байдалтай аж төрдөг хүн. Тэр маань өглөөний есөөс оройн арван нэг хүртэл ажил дээрээ сууж би бол гэртээ хүлээж байдаг юм. Ганцаараа. Гэхдээ энэ гол нь биш. Би түүнээс юу ч нууж чадахгүй, нуух эрх ч байхгүй.

–Тэгвэл битгий л нуу л даа гэж Шарок тайван өгүүлэв.

–Яана гэнэ ээ... Чи бид хоёрын уулзалтын тухай түүнд ярих уу?

–Хэрэгтэй гэж үзэж байгаа бол ярь л даа.

–Би чинь нууц задлахгүй гэж гарын үсэг өгсөн шүү дээ.

–Гэр бүлийн чинь гал голомтын ашиг сонирхлыг бодож чамайг нууц задлахыг би зөвшөөрч байна гээд Шарок жуумалзав.

–Тэгвэл тэр чинь намайг тэр даруй хаячихна. Шарок дал мөрөө хавчив.

–Яасан гэж? Чамайг үүргээ биелүүлж байна гэж тэр үү?

Бүсгүй Шарок руу бүлтийхээрээ бүлтийн харав.Өөрийг нь энэ тухай хэнд ч, хэзээ ч хэлэхгүй гэдгийг мань хүн маш сайн ойлгож байгаа шүү дээ. Харин түүнийг тавих хүсэлгүй, нөхрийнхөө тухай мэдүүлэг мэдүүлээд явж байг гэж бодож байгаа төдийгүй түүнийг ингэж албадаж чадна гэдэгтээ хоромхон зуур ч эргэлзэхгүй байгаа аж. Бүсгүй ямар ч гэсэн,

–За яахав, би түүнд бүх юмаа ярина аа гэж хариулав.

Цаадах нь ярвайн хямсайж,

–Ярь, ярь... Бид бас нэмж яримз. Чиний бүх гадаадынхныг тоочно. Чи тэгээд тэр гадаадынхных чинь ямар байдгийг түүндээ ярьж өгнө биз... Тэд нартай унтахад бодвол илүү зугаатай байдаг байлгүй... гэв.

–Юра, чи юу ярьж байна аа? Цаадах нь ширээ шаан хашгирч,

–Би юу ярьж байгаагаа мэдэж байна!.. Чи муу янхан, тэд нартай унтаж, өрөө дамжин самуурсаар байгаад гадаадын тагнуулуудад хамаг гар хөлөө хүлүүлчихсэн шүү. Толгойгоо далд ортол зоогдсон гэж мэд. Тэд нарт чинь хүн шохоорхох юм юу байдгийг тэр хар хүн шүү юмандаа ярьж өгөөрэй л дээ, цаадах чинь сонсог гэв.

–Юра, чи яаж ийм юм ярина вэ? Би чинь тэр улсыг зөвхөн ширээний ард байхыг нь л харсан шүү дээ.

–Худлаа ярь! Чи тэдэнтэй унтсан. Сүүлчийн удаа гэхэд л шведтэй унтсан. Бид түүнийг чинь мэднэ, түүнээс өмнөхийг нь ч толгой дараалан мэднэ. Чамд юу вэ, манайхны оросууд дугаа юу! Манай оросууд юугаараа дор юм бэ, хэлээд орхи!

Энэ нөхөр арай эелдэг байж болохсон биш үү, өөрөө орос юм чинь өөртэй нь бас унтсан шүү дээ. Гэвч Вика түүний гарцаагүй мэдлэгт балмагдан дуугүй байв.

Гэтэл цаадах нь түүнийг ад үзсэн нүдээр шоролж,

–Ай, ай, нөгөө зүгээр л аавын танил алдартнууд... Профессор Крамер, Россолини, Курт Зандерлинг хэмээн илт сэжиглэсэн дуугаар өгүүлээд, –“Авьяаслаг хийлчид”, ай ай, Фриц, Ганс, Михель... Яг л хамаатан садан шигээ дуудацгаадаг билүү. Хөөрхий муужгайнууд! Гэтэл тэр муужгайнууд чинь нацистуудын намын идэвхтэй зүтгэлтнууд, фашистууд, тагнуулууд! Бас чиний нийлж архидаад байдаг японууд чинь мөн ялгаагүй толгой дараалан тагнуул, зүгээр ч үгүй томчуул, хурандаа цолтой хүн ч бий. Тэд яах гэж манайд ирцгээдэг, бидэнд яагаад тийм их хайртай байгааг чи мэдэхгүй юу? Чи тэд нартай заваарч заваарчихаад одоо болохоор намайг тавьчих, тэгэхгүй бол нөхөртөө хэлнэ шүү гээд явж байна гэнэ ээ. Үгүй ээ, хонгор минь, чамаар яриулахгүй, бид өөрснөө ярьж өгнө, тэгээд чамтай суух нь уу, үгүй юу харна даа! гэж зүхэв.

Вика тэгэхэд нэгэнт өнгөрч яах ч аргагүй болсон мэт дув дуугүй болсон юм.

Харин одоо Маросейкаар явж байхад нэгэнт өнгөрчээ, арга баригджээ гэж огт бодогдохгүй.

Оёдолчин муу жулдрай эндүүрсэн байлгүй! Түүнээс болж өөрөө илчлэгдлээ. Нөхрөөрөө болгоод итгүүлж чадаагүй ч гэсэн өөр бусад шалтгийг тэр муу харгалзахгүй хаачих вэ дээ. Харгалзаж л таарна даа Юрочка минь, харгалзаж л таарна. Вика ням гарагт түүн рүү утасдав.

–Юра сайн уу, Вика байна, чамтай яаралтай уулзах хэрэг гарлаа.

–Юу болчихоов?

–Утсаар ярих юм биш. Чамайг зөвшөөрвөл би танайд очъё, эсвэл гадаа уулзаад жаахан явцгаая.

Вика Маросейка руу очихоосоо айж байжээ. Шароктой хоёулхнаа байна гэхээс айдас нь хүрнэ. Гэтэл Шарок ч гэсэн өнөөдөр Маросейкад очих ээлж нь биш учраас тийшээ очъё гэж хэлж чадсангүй. Тэрээр Вика дахиад л нөхрийнхөө тухай үглээд салахгүй гэж ойлгож байсан учраас ер нь гойд яарахын хэрэгцээ алга хэмээн боджээ. Гэтэл Викагийн шаргуу шахаад байгаагаас ямар нэг санаа зовсон байдал илт байв. Гэвч мань хүн уцаарлан,

–Юундаа яараад байгаа юм бэ? Цагаа болохоор уулзаж ярилцъя гэв.

–Энэ хойшлуулж болохгүй зүйл. Хойшлуулбал чамд л ашиггүй юм болно гэж Вика өөрийнхөөрөө зүтгэв.

–Гайгүй гайгүй, тэвчиж үз.

–За тэгвэл яахав, би л чамд хэлдгээ хэллээ, хожим хар толгойгоо буруутгаарай хэмээн Вика зэвүүн өчив.

–Наадах чинь юу гэсэн үг вэ, занаж байна уу?

–Юу гэж л боддогсон дураараа бол. Би чамаас эцсийн удаа асууж байна. Чи одоо Арбат руу гараад ирж чадах уу?

–Яг одоо юу?

–Цагийн дараа ч болно, хоёр цагийн дараа ч болно, тохиромжтой цагаа хэл.

–За яахав, цагийн дараа Нохдын талбай дээр уулзъя. Надад тэр зүгт явах хэрэг байгаа юм.

Вика цэцэрлэгт талбайн хоосон вандан руу зааж,

–Сууцгаах уу гэж санал болгов.

–Үгүй ээ, энэ гудмаар явъя. Би Воровскийн гудамж руу очих ёстой гэж Шарок зэрөв.

Тэр хоёр Трубниковын хөндлөн гудмыг өгсөв.

–За тэгээд юу болчихоов?

–Юу болчихоов ий? хэмээн Вика асуултыг нь жуумалзан давтаад, –Юрочка чи бид хоёрын уулздаг байрыг янаг амрагуудын болзооны байшин болгох хэрэггүй юм гэж хэлэх гэсэн юм гэв.

Вика тэнд Ленатай тааралджээ гэдгийг Шарок тэр даруй ойлгов.

Гэвч цаг хожих санаатай,

–Юу юу гэнэ ээ? гэж сөргүүлж асуув.

–Шатны тавцан дээр би Лена Будягинатай тааралдсан. Тэр ч байтугай мэндээ мэдэлцэцгээсэн, эрхбиш дунд сургуулийн найз охид юм чинь. Би яах гэж чам дээр ирж очдогийг цаадах чинь мэдээж гадарлаа шүү дээ. Чамайг хаа ажилладгийг мэддэг юм байгаа биз дээ. Тэгэхлээр миний нууц тайлагдчихжээ. Одоо ийм ажилтны хэрэг чамд байхгүй. Найз нөхөд чигээрээ салцгаая.

Юра түүнийг чимээгүй сонсох зуур байдлыг эргэцүүлэн бодож явав. Лена гэж нэг усан толгойт л будлиад нэг цагийн өмнө хүрээд ирсэн хэрэг! Яг тэгсэн байх нь. Викатай улайм цайм мөргөлдчихөөд гоморхсондоо өөртэй нь уулзахгүй гээд байгаа юм байна, тэр чигээрээ тонилбол таарна! Яршиг төвөг удахаас өөр нэмэргүй амьтан. Гэхдээ Викагийн энэ жүжиг бас бүтэхгүй, муу тэнэг эм айлган сүрдүүлэх санаатай гэнэ!

Вика гэнэтхэн түүнийг сугадан авч инээмсэглээд нүд рүү нь ялдамхан харав.

–Юрочка минь, битгий уурла! Чамд яльгүй алдаа тохиолдчихлоо, гэхдээ чи ухаантай эр юм чинь сайхан зохицуулчихна. Тэгэхлээр энэ алдааны тухай хэн ч мэдэхгүй өнгөрнө. Харин надад л төвөгтэй юм боллоо. Одоо би хаагуур ч явж чадахгүй, харсан хүн болгон надаас дөлж зугтах нь мэдээж, тэгэхлээр гэртээ сууж байхаас өөр аргагүй болчихлоо гэв.

Юра гараа булааж авсангүй. Цаанаа л нэг сэргэлэн эм шүү, үгүй тэр шаргуу болоод өршөөлгүй байж байгааг нь, хэлэх юм алга. Уул нь өөрт нь нөгөөдөх шиг үхээнц амьтан биш чухам ийм л хүүхэн хэрэгтэй юмсан! Энүүнтэй бол мань хүн мөн ч дээшээ явна даа. Нөгөөдөх нь хэдийгээр Будягины охин ч гэсэн тэр Будягиныг нь аль хэзээний Бутырын шоронд нэг өрөө хүлээж байгаа, харин энэ нь бол аль ч талдаа хал балгүй профессорын охин...

Гэвч энэ тухай бодол нэгэнт оройтжээ.

–Үгүй, чиний толгойд өөр нэг бодол орж ирсэнгүй юу? Лена чамайг харчихаад миний нууц амраг гэж бодсон юм биш үү?

Вика зогтусахад Шарок ч бас зогсохоос өөр аргагүй болов. Хүүхэн инээмсэглэхээ больчихоод энэрэлгүй саарал нүдээрээ нэвт сүвлэх мэт ширтэж байв.

–Чи намайг нэг муу тэнэг хүүхэнд бүү тооц! Би балмагдаж самгардсан учраас Дьяковын арганд орж нэг цаас шургуулахлаар нь гарын үсэг зурчихсан юм. Гэтэл чи чинь эрхбиш

Дьяков биш шүү дээ, муу ч сайн ч чи бид хоёр хар багаасаа бие биеэ мэднэ, чи бол миний ахын нөхөр, манайхаар орж гардаг хүн, энэ бүхний хажуугаар надтай бас унтсан... Намайг өмгөөлж хамгаалбал чадах л байсан, гэхдээ хамгаалаагүй. Одоо бол би чамайг хамгаалахгүй, тэгж мэдээрэй. Чамайг Старосадын хөндлөн гудамд завхайрдаг газар бий болгож өөрийнхөөрөө нэг нууц амрагт намайг илчилсэн. Тэр нууц амраг нь ардын комиссарын орлогчийн охин, миний багаасаа үерхсэн найз гэж захианд бичээд Ягода руу явуулчихна. Тэр захиаг биччихсэн бэлэн байгаа. Хэрэв чи намайг баривчлаад аваад явчих юм бол тэр захиа явдаг мөрөөрөө яваад өгнө. Үүнийг бодолцоорой.

—Чамайг барьж аваачих юм гэнэ хэмээн Шарок шазуур зуун өгүүлж,

—Чи хэнд хэрэгтэй юм бэ? гэв.

Тэгснээ түрүүлээд хөдлөв. Хүүхэн зэрэгцэн алхсан боловч түүнийг сугадсангүй.

—Хэрэггүй бол сайн л биз, ингээд хоёр тийшээ болцгооё. Би эцсийг нь хүргэж байж сална, ямар ч саад тохиолдсон давахаа л нэг давна, заяа нь ухрахгүй.

—Өө тийм үү, яасан аймаар юм бэ!

Вика түүний хэлснийг үл тоомсорлон өөрийнхөөрөө зүтгэж,

—Би бүх зүйлийг шударгаар хийж байсан. Ой гутмаар хүмүүстэй, нөгөө Либерман энэ тэртэй уулзаж явлаа. Гэтэл чи намайг садар самууныхаа явдлаас болоод илчилчихлээ. Энэ явдал чиний дарга нарт хэр аятайхан санагдахыг харцгаая л даа гэв.

—Чи битгий заналхийлээд бай, тэгэхийн хэрэггүй. Энэ чинь чамд ус болохоос тус болохгүй хэмээн Шарок тамшаалан хямсалзав.

—Чи ч гэсэн намайг заныхын хэрэггүй, би юунаас ч айхгүй байна. Би нөхөртэй болж амьдралаа зохиосон, тэгэхлээр тэр амьдралаа хамгаалах л болно. Би үхвэл үхнэ л биз, харин чиний дэвших хөг чинь бас өнгөрнө, чиний энэ хэргийг цаадуул чинь хэрхэвч өршөөхгүй. Хэрвээ чи хэрсүү хандах юм бол энэ явдал чи бид хоёрын хооронд үлдэнэ. Надад итгэж болно шүү.

Энэ удаа Шарок зогтусаж,

—За тэгэхлээр Лена үнэхээр чамайг харсан байна лээ, над руу ёстой бууж гарсан, тэгээд би ч чи бид хоёрын хооронд янагийн явдал байсан гээд үнэнээ хэлчихсэн, явдал байсан нь үнэн юм чинь тийм биз дээ?.. Чамтай дахиад яасан ч уулзахгүй гэж би түүнд ам өчгөө өгсөн. Тэгэхлээр чи санаа зовохгүй байж болно. Лена энэ тухай нэг ч хүнд хэлэхгүй. Энэ талаас чамд ямар ч аюул занал үүсэхгүй. Чиний захидлын тухайд гэх юм бол тэр чинь зорилгоо биелүүлж чадахгүй. Лена бол хэрэг дээрээ миний авгай, чи түүнтэй мөргөлдчихсөн байна, ийм явдал байх шүү дээ, тэгэхлээр манай авгайгаас тэр нууцыг задлахгүй гэсэн гарын үсэг авчихъя, тэгээд л энэ явдал дуусах нь тэр. Чи захиа бичвэл зөвхөн ганцхан үр дүнд хүрнэ. Юу вэ гэхлээр чамайг өөр хүнд л шилжүүлээд өгчихнө, тэглээ гээд чамд дээрдэнэ гэдэгт би нэг

их итгэхгүй байна гэв.

Вика биеэ барьж ядан түүнийг сонсох зуур ичгүүр сонжуургүй дүрлэгэр саарал нүдээрээ яг түүний нүд рүү ширтээд байв.

Тэгснээ хорсолтой бөгөөд эрс шийдэмгий дуугаар,

–За тэгвэл яахав, хоёулаа мөр мөрөөрөө явцгаах болох нь. Сайн сууж байгаарай гэв.

Гэвч цаадах нь түүнийг барьж тогтоогоод,

–Байз л даа, бас өөр нэг тал байгаа юм. Өнгөрсөн удаа чи намайг энэ ажиллагаанаас чөлөөлж өгөхийг ч хүссэн. Тийм хүсэлтийг би даргадаа илтгэх ёстой байсан юм, тэгээд яг тэр өдрөө мэдээлэл бичсэн. Ямар дүн гарахыг би мэдэхгүй байна. Жаахан тэвчиж бай гэв.

Шарок энэ бүхнийг сая зохиож бодсоноос биш дээш нь бичсэн ямар ч мэдээлэл энэ тэр байхгүй, харин одоо бичиж магадгүй, тэгэхлээр өөрийнх нь хэлснээс айж байгаа хэрэг гэж Вика бодсон боловч,

–Би хэр удаан хүлээх ёстой болж байна? гэж асуув.

–Бидний дараачийн уулзалт дээр хариугаа аваарай.

Арав хоног хүлээх нь! Дахиад л нөгөө байр луу санжганах хэрэг үү?

–За тэгье, би арав хоног хүлээе гэж Вика хэллээ.

Вика одоо ухрахаа үзэхгүй. Уран барилгачийн авгай болчихоод өөрийнхөө талыг их хүчтэй болсон гэж сэтгэж байх шив. Хүч бол түүнд биш мэдээж нөгөө талынханд байгаа, гэхдээ Вика ичих нүүргүй, яахаас ч буцахгүй улайрсан амьтан. Түүнээс гадна Юра өөрөө үнэнийг хэлэхэд түүнд бас ч гэж идэш өгчихсөн.

Тийм учраас Шарок Дьяковг дурссан нь зүйтэй гэж үзээд,

–Виктория Андреевна Марасевич Уран барилгачтай суусан, тэгээд нөхрийнхөө нүүрэн дээр ариухан охин шиг байх санаатай гэнэ гэж хэлжээ.

–Гуйж гувшаад байна уу?

–Либерманы бүлгээс харилцаагаа тасалсан, хуучин найз нартайгаа уулзахаа больсон, ресторан явахаа зогссон, гэртээ л суугаад байгаа. Гэтэл одоо хэр шинэ танил алга. Тэгэхлээр нэг хэсэг хугацаанд түүнийг сул тавьдаг юм билүү, өөрийнхөө шинэ нөхцөл байдалд дасан шинэ хүмүүсийн дунд орж, шинэ танилуудтай болж байг. Уран барилгачийн бараанд олон хүн бий, бас сонирхолтой ч хүмүүс бий.

–Энэ зүйтэй, нэг хэсэгтээ сул явж байг хэмээн Дьяков зөвшөөрөөд,

–Одоо ийм юм, Шарок... гэснээ ширээн дээрх цааснуудаа эмхлэв. Энэ нь хэлэх үгээ эргэцүүлж, бодлоо төвлөрүүлж байгаа хэрэг билээ.

–За тэгэхлээр, энүүхэн хоорондоо ярьж байна шүү гээд Дьяков Шарок руу тун нухацтай харснаа,

–Ленинградаас нөхөр Запорожец ирсэн, тэгээд төв аппаратаас гурав дөрвөн найдвартай залууг Ленинград руу өөртөө авах санаатай гэнэ. Мэдээж цол, цалин нэмэгдэх дээгүүр албан тушаалд авна гэсэн үг. Товлож байгаа хэдэн хүний дотор чиний нэр бас явж байгаа. Чи үүнийг юу гэж бодож байна? гэж асуув.

Шарок дал мөрөө хавчлаа.

–Би юу гэж бодох вэ дээ? Хаашаа л яв гэж тушаана тийшээ л явна. Москвагийн байр маань миний нэр дээр хоцорно гэж найдаж байна.

–Тэгэлгүй яахав, тэр байранд чиний эцэг эх сууцгааж байгаа юм чинь. Орон нутагт нэг хоёр жил ажиллахгүй юу, гэхдээ энэ ч ямар юмных нь орон нутаг байх вэ дээ? Хоёрдугаар нийслэл. Буцаад ирэхдээ том цолтой болчихсон, өндөр албан тушаал дээр бууна. Бодож үз л дээ! Энэ бол тушаал биш сайн дурын хэрэг. Запорожец бол өөрийнхөө залуучуудад хир хүргүүлдэггүй, хөгжилтэй сайн хүн. Түүнтэй ажиллах хүсэлтэй хүмүүс зөндөө бий. Энэ бол урьдчилсан яриа. Тэр чамтай өөрөө ярилцана, магадгүй өөр хүн авахаар болчихож ч мэднэ. Чи бод, минийхээр бол ирээдүйтэй л хэрэг шиг санагдах юм.

Санамсаргүй ч гэсэн сонирхолтой санал. Бүх насаараа төв аппаратад шигдэж байж болохгүй, тийм ёс ч байхгүй, хэсэг хугацаанд орон нутагт ажиллаж тэндхийн ажлын бодитой туршлага эзэмшээд Москвад ирэх хэрэгтэй. Ленинград бол хамгийн сайхан боломж, зах хязгаарын аль нэг бөглүү нүхтэй яаж зүйрлэх вэ” Үүнээс гадна Москвагаас ганцхан шөнө явах газар. Бас Запорожец Медведь өвгөний халааг удахгүй авах байх. Тэгэх юм бол түүнтэй хамт мань Шарок өөрөө бас дээшилнэ. Ер нь өөрөө энд нэг түшиг тулгууртай байх хэрэгтэй. Дьяков бол түшиг тулгуур биш жижигхэн хүн. Березин! Уул нь ч том толгой л доо, даанч хэл амаа олохгүй байгаа юм, тэгэхлээр түүнийг Алс Дорнод руу шилжүүлэх байх. Харин Алс дорнод руу явах юм уу, за больё, Ленинград нь дээр.

Нэг үгээр хэлбэл тэр санал Шарокт аятайхан санагджээ. Бас Ленатай хар аяндаа харьцаа тасарна. Ахтайгаа ч гэсэн тэр. Ахынх нь хугацаа дуусаад ирэх болж байгаа, өөрөө аяа олно биз, мань хүн тус болж чадахгүй.

Шарок Маросейкад Викаг тун сайхан зантай угтлаа.

–За хонгор минь, магнайгаа тэнийлгэ, чамайг бид дуртай зүгт чинь тавилаа. Ленагаас болсон юм биш шүү. Чамайг манай авгайтай мөргөлдчихсөн гэдгийг би илтгээд энэ асуудлыг бас зохицуулчихсан. Чамайг гэрээсээ гардаггүй үлгэр жишээ авгай болсон, ийм хүний нэмэр гэж юу байх билээ? гэж би дарга нартаа учирласан. Тэд нар миний хэлснийг зүйтэй гэж үзсэн учраас л бидний уулзалтыг цуцалж байгаа юм. Бурман сарынхаа жаргалыг эдэлж үз.

–Баярлалаа гэж Вика тогтуухан хариулаад

–Миний үүрэг яах вэ? гэж асуув.

–Үүрэг ий? Архивт өгчихсөн. Чи буцааж авмаар байна уу?

–Тийм.

–Чи мөн дураараа шүү! Хавгаст хэргээс баримт тасдаж авахыг хэн зөвшөөрөх юм бэ? Хуудсаар нь дугаарлаад архивт тушаачихсан, одоо түүнийг чинь оготно уншиж байгаа.

Тэр цаас хүзүүнд нь угласан урхи мэт өөрийг нь аргамжиж байх болно гэдгийг Вика ойлгож байв. Гэвч энэ зуур чөлөөлөгдлөө, цаашид хэрхэхийг яван байж харъя.

–Юра, баярлалаа хэмээн Вика босож өрөөг тойруулан гараараа дохиод, –Ийм байдалд, ийм үүрэгтэйгээр чамтай хэзээ ч уулзахгүй байх гэж найдаж байна гэв.

–Хэзээ ч уулзахгүй хэмээн Шарок инээмсэглэн нотлов.

Энэ бол чин санааны хариулт. Тэрээр дахиад хэзээ ч Вика Марасевичтэй ажиллахгүй. Шаардлага гарвал өөр хүн түүнтэй ажиллах болно, шаардлага гарах нь дамжиггүй.

Мань хүн өөрөө бол Ленинград явахаар дотроо аль хэдийн бэлтгээд эхэлжээ. Тэрээр хэзээ ч Ленинград орж үзээгүй. Дунд сургуулийнх нь олон нөхөд тэнд төрөл садан, танил талтай, амралтаар тийшээ явцгаадаг, Ленинградад амралтаа өнгөрөөнө гэдэг бол ёстой мундаг хэрэг

байсан, харин өөрт нь Ленинград таних мэдэх хүн огт байгаагүй билээ. Тэрээр Арбатын сэхээтнүүдийн энэ байдалд, үгүй зөвхөн энэ ч биш тун олон юманд нь атаархдаг байсан. Одоо мань хун ч гэсэн Ленинград явж байна, гэхдээ хамаатныдаа толгой хоргодохоор биш хариуцлагатай ажил хийхээр явж байна. Эхлээд нэг хэсэгтээ зочид буудалд сууна, дараа нь байр өгнө.

Шарок яг тэр өдрөө Березинээр хэдэн бичигт гарын үсэг зуруулахаар өрөөнд нь орж таарав. Березин гарын үсэг зурчихаад,

–ДЯАКГ-ын дээд сургуульд хүмүүс элсүүлэх гэж байгаа. Сурах хүсэл танд байна уу? гэж асуув.

Шарок балмагдчихав. Дээд сургууль гэдэг бас л дотор гижигдсэн зүйл, дээд шатны ажилтан бэлтгэнэ. Тэгвэл Ленинград яах вэ?

–Би сайн мэдэхгүй байна. Нөхөр Запорожец намайг өөртөө Ленинград руу авах гэж байгаа шүү дээ гэж Шарок итгэл муутайхан өчив.

Березин түүнийг анхааралтай харснаа тэргүүнээ гудайлгаж хараагаа буруулав.

–Тэгвэл өөр хэрэг, асуудалгүй боллоо.

Түүний царайнаас бодлыг нь тайлахын аргагүй байлаа.

Шарок тэдний өрөөнөөс гарлаа. Березин араас нь хаалгаа түлхүүрдэн цоожлов. Тэгээд тэр хэлхээтэй түлхүүрнүүд дотроосоо өрөөний буланд буй нууцын шүүгээний түлхүүрийг олж онгойлгоод хажуудаа сандал тавьж шүүгээнээс гаргасан хавтаснуудаа нэг бүрчлэн үзэж сандал дээр давхарлан тавьж эхлэв.

Тэг тэгсээр хайж байсан хавтсаа олж хажуу тийш нь тавиад бусдыг нь хуучин дарааллаар нь шүүгээндээ буцааж өрөхдөө саяын авсан хавтсаа сүүлд яг байранд нь хийхийн тулд байсан газар нь цаас хавчуулав.

Тэрээр хавгаст хэргийг анхааралтай шүүсээр хэрэгтэй хуудсаа онгойлгов... Тамхиа асаалаа.

Шарокоос санаандгүй сонссон мэдээ нь Ленинград ямар нэг ажил явуулга бэлтгээд байна уу гэсэн түүний хардлагыг нотолжээ.

Алфёровыг Зүүн Сибирь лүү шилжүүлсэн явдал тийнхүү хардахын анхны сэжиг болсон билээ. Уул нь Алфёровыг Киров өөртөө авах гэж гуйсан шүү дээ. Гэтэл Алфёровын Хятадад байх үеийн үйл ажиллагааны зарим нэг талыг тодруулах хэрэгтэй, одоохондоо Сибирьт суузгаж байг гэх маягийн үндэслэл гаргаад Ленинградын оронд Ангара руу районы бүрэн эрхт төлөөлөгчийн албанд хөөчихсөн юм. Тэр ч байтугай Алфёровыг Москвад ч ирүүлээгүй, Канскт буух тушаал өгөөд тэндээс нь район руу явуулчихсан гээч.

Алфёровын оронд Ленинград руу Иван Запорожец яваад өгчээ. Тэрээр нуруу өндөр, мөр өргөн, “царигтай эр”, хэл ам хурц, алия наргиа зантай, дарс, хүүхэн хоёрын чансааг сайн

мэддэг, сайхан дуулдаг нэгэн болой. Палихад аж төрдөг, нэг удаа байранд нь усанд орох онгоц байхгүй гэж гомдол мэдүүлсэн явдал бий, эхнэр нь яншаад тэр тухай амар заяа үзүүлэхгүй байсан гэдэг, авгай нь ёстой сайхан хүүхэн, Роза Проскуровская...

Березин дахиад ширээ рүүгээ тонгойж Запорожецийн хавгаст хэргийг шүүж үзлээ. Хуучин зүүн эсер явсан атлаа Онцгой комиссын төв аппаратад үлдчихсэн байгаа юм. Мэдээж, Ягода л хамгаалж хоцроо л доо, тэр хоёр салж хагацах цаг гэж байх биш. Запорожецийн гүйцэтгэсэн ажиллагааны жагсаалт дотроос хамгийн тоймтой нь түүнийг Махногийн[15] штабт тагнуулаар явуулсан хэрэг юм. Аз нь гозойж явдаг алмад этгээд. Одоо нэг шинэ балмад явуулга бэлтгэж байна. Запорожецийн гар дор байдаг Березиний өөрийнх нь талын нэг хүн Николаев гэгч нэг этгээдийн замаас нь барьсан захидлын хуулбарыг түүнд шилжүүлж өгсөн юм. Сэжиг төрмөөр хачин захидал... Березин тэр захидлыг дахин нэг уншив.

Леонид Николаев. 1920 онд арван зургаан настайдаа фронтод намд элссэн. Ажилчны гэр бүлээс гаралтай, өөрөө ч бас ажилчин байсан. 1934 он хүртэл Ленинградын Ажилчин тариачны байцаан зааварлах газар үнийн байцаагчийн албан тушаалд ажиллаж байсан. Николаевын өөрийнх нь бичсэнээр бол мужийн намын хороонд шургалсан троцкистуудын явуулгаар түүнийг Ажилчин тариачны байцаан зааварлах газраас зайлуулж үйлдвэрт шилжүүлжээ. Гэтэл үйлдвэрийн намын үүрийн нарийн бичгийн дарга гэж бас нэг троцкист түүнийг намын дайчилгаагаар тээвэрт илгээжээ. Тэрээр намын яв гэсэн газар хаа ч очиж ажиллахад бэлэн байгаа боловч нам биш, өөрийг нь Ленинградаас хөөх гэсэн троцкистууд ийш тийш нь явуулж байна. Тийм учраас хотоос явахгүй гэж татгалзжээ. Үүний улмаас намаас хөөгдөж гуравдугаар сараас хойш ажилгүй байгаа ажээ. Нөхөр Кировг өөрийнхөө хэрэг явдлын учрыг олж өгөхийг хүсэн хорин захидал явуулж, мөн Ленинградын аппаратад троцкистуудын нөлөө давамгайлж байгаа тухай бас нөхөр Кировг бичжээ. Тэгээд нэг ч хариу аваагүй. Нэг бол нөхөр Киров хариулах шаардлагагүй гэж үзэж байгаа, нэг бол захидлууд нь нөхөр Кировг хүрэхгүй байгаа хэрэг. Үүний буруутан нь Кировын сохроор итгэж өөрийгөө хүрээлүүлсэн троцкистууд. Николаев өөрөө насалсан гучин насныхаа арван дөрвөн жилийг намд өнгөрүүлсэн, намгүйгээр цаашид яаж амьд явах нь толгойд нь багтахгүй байгаа болохоор арга барагдан мухардсан учир яахаас ч буцахгүй болсон...

“Яахаас ч буцахгүй болсон...” Энэ юу гэсэн үг вэ?

Амиа хорлох нь уу? Ингэж айлгаад хэн ч тоохгүй гэдгийг намд арван дөрвөн жил болсон хүн ойлгож байгаа. Алан хядах ажиллагаа хийх нь үү? Ийм юмны тухай бичдэг ч үгүй, урьдчилан анхааруулдаг ч үгүй, ингэж сүрдүүлсний төлөө буудан алдаг. Гэтэл биччихсэн, сүрдүүлж байна шүү дээ. Ухаан солиотой юм болов уу?

Түүний энэ сүрдүүлэг хэнд зориулагдсан зүйл вэ? Бас хамгийн гол нь энэ хүнтэй Запорожец ажиллаад байгаа юм. Тэр юунд хэрэгтэй байх вэ?

Запорожец шинэ хүмүүсийг Ленинград руу ямар албан тушаалд авах гэж байгаа юм бол? Тэд нар хэний оронд очицгоох вэ? Ямар зорилготой тэр вэ? Яагаад ийм нууц хийж байна? Березин хүртэл өөрөө коллегийн гишүүн мөртлөө энэ тухай санамсаргүй олж мэдлээ.

Сталин Ленинградын байдалд сэтгэл дундуур байгаа нь нийтэд илэрхий зүйл.

Зиновьевынхны эсрэг бүлгийнхэн гэгчийн эсрэг залхаан цээрлүүлэх ажил явуулахыг Кировоос шаардаж Ленинградад аллага хядлага дэгдээх санаатай байгаа. Яах гэж тэр билээ? Улс орон даяар аллага хядлага дэгдээх эхний аянга болгох гэж гэр уу? Киров татгалзаад байгаа болохоор Запорожец үүний эсэргүүцлийг давахад тус болох хэрэг өдүүлэх зорилготой бололтой. Гэхдээ Запорожец юу ч зохион байгууллаа гэсэн мөрдөн байцаах ажлыг Ленинградад л явуулна. Киров мөрдөн байцаалтыг гараасаа гаргахгүй, ийм ажил дээр мань хүн ухрахаа үзэхгүй, шаардлагатай бол асуудлыг Улс төрийн Товчоонд оруулна.

Тэгэхлээр Запорожец бүх нийтийг палхийтэл цочоож Киров ч ухрахаас өөр аргагүй болох нэгэн зүйлийг зохион байгуулах ёстой болох нь.

Гэтэл энэ нь юу байж болох вэ? Хорлон сүйтгэх ажил уу, дэлбэлэлт үү, төмөр замын осол уу? Кировыг ийм юмаар дийлэхгүй! Түүний аль нэг хамтран зүтгэгчийг алах нь уу? Чудовыг уу, Кодацкийг үү, Позерныг үү?.. Ийм зорилгоор Николаевыг хадгалж байх нь уу? Энэ бол дуулиантай юм болно, гэхдээ ямар ч байсан Кировыг мөрдлөгийн ажлаас хөндийрүүлж чадахгүй. Тэгвэл юу байх вэ?

1918 онд Царицынд байхдаа Сталины өөрт нь хэлсэн үгийг Березин сайн санаж байгаа билээ. Сталин хаант засгийн армид офицер агсан цэргийн хэдэн мэргэжилтнийг буудан алахыг шаардсан ажээ. Тэр үед онцгой хэлтсийн дарга байсан Березин, тэдэнд тулгасан ялыг үнэмшил муутай байна, тийм учраас буудан албал баахан төвөгтэй хэрэг мандаж бөөн асуудал үүснэ хэмээн Сталинд нотлохыг оролджээ. Сталин хариуд нь,

–Үхэл бүх асуудлыг шийддэг юм. Хүн нь байхгүй бол асуудал нь ч байхгүй гэж сургамжилжээ.

Тэгээд Сталины зөв болж таарсан юм. Буудан алах ялыг цуцлах тухай цахилгаан ирэхэд нөгөө хэдийг аль хэдийн хороочихсон байжээ. Гэтэл ямар ч асуудал үүсээгүй.

Энэ хүний философи ийм билээ. Одоо түүнийгээ хэрэглэх болов уу, яах бол? Хэрэглэнэ, гарцаагүй хэрэглэнэ! Березин өөрөө ил хэлж чадахгүй, цорын ганцхан болгоомжгүй үг хэллээ гэхэд л мань хүн үйлийн үргүй арчуулна. Гэхдээ урьдчилан анхааруулах боломж өөрт нь байна.

Березин орой нь Будягиныхаар оров. Тэднийхэн Зөвлөлүүдийн тавдугаар байшинд өөр өөр орцонд аж төрдөг агаад хэдийгээр бие биеэ таних төдий, бас ховорхон уулздаг боловч амьдралын адилхан зам туулсан, нэр алдар, эрх тушаал горилохыг огтхон ч мэддэггүй ахмад большевикуудын бат найдвартай жигүүрт хоёулаа хамаардаг тул хоёр биеэ талархан харьцдаг байжээ.

Березин элдэв сэжиг ажгийн тухай Будягинд юу ч хэлсэнгүй. Тэднийхээр хэзээ ч орж байгаагүй Березин дуртай номын сангаасаа захиалаад авч болох Алс Дорнодын эдийн засгийн тухай ном сураглаж яваа дүрээр анх удаа орж ирсэн нь Будягинд бүх зүйлийг тодорхой болгожээ. Тэр хоёрын ярианы явцад Иван Запорожец Ленинград руу татахаар өөрийнхөө хүмүүсээс нэг бүлэг бүрдүүлж, энэ нь маш нууцаар хийгдэж байгаа тухай Березиний дурдах төдий хэлсэн зүйлийг ч Будягин ойлгохын цаагуур ойлгов.

Будягин Березинийг үдэж гаргаад гал тогоо руугаа орж өөрөө аагтай цай чанав. Ашхен Степановна хол яваа нь даанч тоогүй, түүнээс биш Березины мэдээлсэн түгшүүртэй мэдээг авгайтайгаа эргэцүүлж яримаар санагдав. Будягин өглөө нь өөрийнхөө тасалгааны хажуугаар өнгөрч Сёмушкин руу ороод, Оржоникизегийн өрөөний хаалга руу дохиж,

–Байгаа юу? гэв.

–Байгаа гэж Сёмушкин хариулав. Будягин Ленинград руу Запорожецид шинэ хүмүүсийг томилж явуулж байгаа тухай Оржоникизед ярихдаа Березиний нэрийг дурссангүй. Иймэрхүү ажил дээр мэдээний эзнийг дурддаггүй билээ.

Оржоникизе бодлогошров. Хэрвээ энэ шинэ томилолтууд нь ДЯАКГ-ын аппаратын дотоод дахь ердийн явуулга бол тэр тухай мэдээллийг Медведь Кировт илтгэсэн байх ёстойсон. Гэтэл сонирхсон хүмүүс энэ тухай Будягинаар дамжуулан өөрт нь, Улс төрийн Товчооны гишүүн, Кировын хувийн найз хүнд мэдээлж байна. Тэгэхлээр энэ мэдээлэл бол байгууллагын дотоодын чанартай биш түгээмэл улс төрийн шинжтэй байж таарах нь.

–Чи энэ тухай юу гэж бодож байна гэж Оржоникизе асуув.

–Ленинградад ямар нэг юм сэдэж байна. Сергей Мироновичийн нэрийг хорлох зорилготой.

–Яаж?

–Хэлэхэд хэцүү юм. Залхаан цээрлүүлэх ажил албадан хийлгэж байна, түүнийг тэгэхээс өөр аргагүй болгох гэж байна. Харин дахиад татгалзах юм бол Ленинградаас зайлуулна.

–Бодвоос тийм бололтой гэж Оржоникизе санал нийлэв.

Мэргэжлийн чекист Березиний дор нь гадарласан нь тэр хоёрын толгойд даанч орсонгүй.

Шүд нь өвчин оржээ. Тэр шүд аль хэзээнээс хөдөлж байгаа боловч хиймэл шүдний дэгээнд овоо тогтож байсан юм. Гэтэл өчигдөр орой Сталин хиймэл шүдээ авахдаа өвчин орсныг мэдэрчээ. Тэрээр шүдээ буцаан углахад дэгээ нь байрандаа орж нөгөө шүдийг тогтоов. Гэхдээ хэлээрээ хөндөж үзэхэд шүд нь ганхаж буйл нь өвдөж байх шиг санагджээ.

Сталин хиймэл шүдээ авалгүй хэвтсэн боловч тэр шөнийг нам тайван өнгөрүүлэв. Өглөө нь хиймэл шүдээ аятайхан авч нөгөө шүдээ эхлээд хэлээрээ, дараа нь хуруугаараа хөндөж үзэхэд тэр нь ганхаж суга татаад хаячих юм уу, хэлээрээ түлхээд гаргаад хаячихмаар эгдүүтэй байв. Сталин Москвагаас шүдний эмч дуудуулахыг тушаалаа. Липман эмч, хиймэл шүдний техникч хоёр онгоцоор ирээд тэднийг гуравдугаар зусланд оруулсан тухай нар тонгойх үес түүнд илтгэв.

–Төвхнөж гүйцмэгц наашаа ирэг гэж Сталин тушаав.

Хагас цагийн дараа эмч ирэв. Дөч шахаж яваа цагаан зантай, сайхан еврей аж. Тэрээр үүнээс өмнө Сталиныг эмчилж байсан, Сталин ч түүнийг сайшааж, тэр ч байтугай “Та ч Шапирог бодвол хөнгөхөн гартай хүн юм аа” гэж хэлсэн удаатай.

Шапиро гэж Липманы өмнө байсан эмч. Бас л сайн мэргэжилтэн. Гэтэл асууж шалгааж тэмтэрч үзэж, хүний хэлснийг сонсож, эм биччихсэн хэрнээ ямар өвчнөөр өвдсөн энэ тэрийг эмчийн ёсоор ярьж тайлбарлаж өгдөггүй, хэтэрхий дүвчигнэн битүү дүрэмдэж, мэргэжлээ нууц далдын оньсого болгодог эмч нарт Сталин дургүй билээ. Дуу ховортой, жижигхэн биетэй Шапирогийн иймэрхүү шинж гойд дургүй хүрэм байсан аж.

Липман бол тэс өөр хүн, юу хийж байгаагаа тайлбарлаж, Сталин ямар шүдтэй болон хиймэл шүдээ яаж арчлах тухай ярьж өгнө. Анх удаа Сталины шүдийг авахдаа Шапиро шиг шууд нулимуур луу хаячихалгүй өөрт нь үзүүлж, тэр шүднийх нь тулга ямаршуухан болчихсон, чухам яагаад энэ шүдийг заавал авах ёстой болсныг харуулсан билээ. Хүнтэй нийцтэй амгалан хүн. Сталин түүний тухай “Сайхан ч сугална, сайхан ч дүйвүүлнэ” гээд хүд хүд инээдэгсэн.

Тэрээр Липман өөрөөс нь эмээдгийг харж байгаа, гэвч хүн болгон айдаг болохоор тэр тухайд хачирхах юм алга. Гэхдээ шүдний эмч айснаасаа болоод гар нь салгалж байвал хахь хамаагүй юм ч хийчихэж мэднэ. Тийм учраас мань хүн Липмантай найрсаг харьцана. Өнөөдөр ч гэсэн урьдын адил,

–Сайн биз дээ, гэр орныхон чинь цөм сайн уу? гэж асуув.

Хэдийгээр Липманы гэр орон, ам бүлийн тухай юу ч мэдэхгүй ч гэсэн ингэж асууж байгаа юм.

–Цөм сайн, баярлалаа, Иосиф Виссарионович гэж хариулаад Липман бараг аяных шиг том чемоданаа нээж багаж хэрэгсэл, толгойн түшүүрээ гаргаж түшүүрийг сандалд бэхлэв. Толгойн түшүүрийг ингэж урьдаар бэхэлдэг нь Сталинд бас аятайхан санагдана. Шапиро бол

Сталиныг суудалд суучихсан хойно түшүүрээ бэхэлдэг агаад ард нь юм оролдоход Сталин хэзээний дургүй.

Липман толгойн түшүүрийг бэхэлж хэр зэрэг тогтсоныг нь шалгаж үзээд Сталиныг урив. Сталин суулаа. Липман түүний хүзүүгээр алчуур хормогчлон зангидаад толгойг нь зөөлхөн түшиж түшүүрийг дэрлүүлэв.

—Эвтэйхэн болов уу?

—Зүгээр.

—Ямар зовиур байна?

—Нэг шүд ганхаад болдоггүй, ялангуяа хиймэл шүдээ авчихлаар бүр горьгүй.

—За одоо хараад орхиё гээд Сталинд шилэн аягатай ус “өгч —Та амаа зайлчих... За зүйтэй... Одоо толгойгоо гэдий дээ... За яг боллоо... гэв.

Липман хиймэл шүдийг нь аятайхан аваад нөгөө шүдийг нь хөдөлгөж үзэв. Хуруу нь зөөлхөн бөгөөд нэг аятайхан үнэр ханхлах аж. Нямбай эмч юм даа... Дараа нь ширээн дээр бэлтгэсэн багажнуудаа үзсэнээ гарын толио гаргаж ирээд шүдийг нь дахин шалгаад,

—Энэ шүдийг авах хэрэг болох нь, өөр зам алга, илүү шүд зовлонгоос өөр юм хайрлахгүй. Хиймэл шүдний бэхэлгээ түүн дээр тогтохгүй байна. Бүүр муудчихсан шүд юм гэж өгүүлэв.

—Энэ чинь хэдий хэр удах вэ?

—За ором нь хоёр гурав хоногт эдгэчих байх гэж найдаж байна, хиймэл шүдийг нэг хоногт хийчихнэ. Ингээд бодоход нийтдээ тав хоногоос хэтрэхгүй биз.

—Би тэгээд тав хоног шүдгүй явах болж байна уу хэмээн Сталин хөмсөг зангидав.

—Хаанаас даа, юу гэж тэгэх вэ гэж Липман инээмсэглэн өгүүлээд, — Та одоохондоо зөвхөн дээд араагүй л байх юм. Тур зуур энэ шүдийг тохируулсан ч болно хэмээн хуучин тагнайтай хиймэл шүд гартаа эргэлдүүлж, — Тэгвэл танд ердөө л ганцхан шүд дутна. Гэхдээ яльгүй ч гэсэн жиширвэл эрүүл шүдний тань ачаалал хэт ихдээд тэр шүдээ гэмтээчихэж болзошгүй. Азаа үзэхийн хэрэг юу билээ? Та хэд хоног тэсэх үү? гэв.

—За яахав гэж Сталин зөвшөөрөөд, —Хэзээ авах хэрэгтэй вэ? гэв.

—Хэзээ ч хамаагүй, одоо ч авсан болох байна.

—Маргааш өглөө бол яах вэ?

—Маргааш өглөө ч болно.

—Өнөөдөр манайд зочин ирнэ, шүдгүй байж зочид хүлээж авах эвгүй, та юу гэж үзэж байна?

–Зочид гийчид юм идэх хүсэлтэй байгаа бол юуны өмнө өөрснөө л шүдтэй байх хэрэгтэй хэмээн Липман инээмсэглэв. Сталин бослоо. Липман хүзүүгээр уясан алчуураа бушуухан тайлж авав.

–Та амар, маргааш өглөө цайны дараа танд хэл өгнө гэж Сталин өгүүлэв.

Киров өдөр иржээ. Сталин түүхийн сурах бичиг бүтээх талаар тэдний хийж байгаа ажлыг Кировг танилцуулаад орой нь үдшийн хоолонд урихыг Ждановт даалгажээ. Сталин, Киров, Жданов гурав хамт оройн хоол идэцгээв.

Сталин гэрийн эзний ёсоор ширээний тархинд тухлан суух зуур,

–Сергей Миронович, чи ирсэн чинь яамай, тэгээгүй бол энэ Андрей Александрович хэмээн Жданов руу дохиж, –юм ч уухгүй, хоол ч идэхгүй, ширээний ард Иисус Христос шиг суучихаад намайг бас өлсгөж цааш нь харуулах гээд байна. Би энэ тухайд гэвэл Чеховтой санал нэг байдаг юм. Бүх төрлийн өвчнийг эмч нар зохиож олсон гэж хэлсэн шүү дээ. Бүх юмыг идэх хэрэгтэй, мэдээж их бишээр, зохих хэмжээ хязгаартай идэх хэрэгтэй. Кинза, тархун, жонжоли... гээд кавказын нарийн ногоонууд ашигтай. Жимс ашигтай, хуурай дарс, гүржийн дарс - сайхан дарс шүү. Ид, уу, бүх юм ашиг тусаа өгнө. Ширээн дээр юу байгаа чи өөрөө харж байна, чи кавказын хүн юм чинь дээ. Эсвэл чи Ленинградад очоод качапури, лобио, сациви[16] гэж юу юу байдгийг мартчихсан юм болов уу? гэв.

–Мартаагүй ээ хэмээн Киров инээд алдаж хариулаад олон төрлийн зууш хоолноос өөрийнхөө таваг руу жаахан жаахан хийж, –Бүгдийг нь санаж байна, би цөмөөрөнд нь дуртай гэж өгүүлэв.

–Одоо Ленинградад хаанахын хоолыг чамирхан хэрэглэж байгааг би мэдэхгүй байна хэмээн Сталин бодлогошрон өгүүлээд, –Дээр үед язгууртнууд франц хоолонд, ардууд хиа, зайдас гээд герман хоолонд дуртай байж билээ. Одоо ямар байгаа вэ? гэж асуув.

Одоо байцааны шөл, хүрэн манжингийн шөл, котлет, хөндий гоймон гээд пролетарийн хоол л гол хоол болж. Бид тасалбараар өгч байгаа юмыг л ардууд идэж байна гэж Киров хариулав.

–Тийм дээ, тасалбар байгаа гэж Сталин түрүүчийн адил бодлогошрон өгүүлснээ, –Цаашдаа тасалбарыг устгана аа гэв.

Киров үүнийг ер тоосонгүй. Хүнсний тасалбарыг нэгдүгээр сарын нэгнээс эхлээд хүчингүй болгоно гэдэг бол нэгэнт шийдчихсэн асуудал байжээ.

–Энэ жил ургац сайн байх төлөвгэй байна, талх хүрэлцэх ёстой. Бид Казахстанас мэдээ авсан, ойрын арав хорин жилд хэзээ ч байгаагүй сайхан ургац гарсан гэж бичигцгээсэн байна, гагаас хорин таван центнер тариа авна гэж найдацгааж байгаа гэнэ. Чиний найз Мирзоян тийм их ургацыг хурааж авч чадахгүй болов уу гэж айж байна гэж Сталин ярив.

–Мирзоян гавшгай хүн, ажил унагахгүй. Сталин Кировын хэлснийг сонсоогүй мэт бодолдоо автан яриагаа үргэлжлүүлэн,

–Баялаг ургац ч мэдээжээр сайхан хэрэг, гэхдээ нөгөө талаас бас муу юм бий. Хүмүүс гэнэднэ, тайвшрах, амарлингуй хандах, цалгардах явдал үүснэ. Баялаг ургацыг бүрэн хурааж, алдаж асгахгүй, идэж шамшигдуулахгүй аваачих газар нь аваачиж баймааж сая сайн ургац авлаа гэж хэлж болно.

Сталин дэмий хоосон юм ярьдаггүй болохоор Казахстаны тухай санаандгүй ярьж байгаа биш гэдгийг Киров мэдэж байв. Сталин хоол ундны үеэр ажил төрлийн юм ер нь ярьдаггүй атал өнөөдөр тийм яриа үүсгэж байна. Их холоос эхэлж, хэний ч мэдээжийн юм ярьж байна. Ингэж байгаад огт санаанд оромгүй зүгт эргүүлдэг барилтай л даа. Бас дахиад л хөдөө аж ахуйн тухай яриа. Нэг сарын өмнө Төв Хорооны зургадугаар сарын Бүгд хурал дээр Киров тариа, махан бүтээгдэхүүн бэлтгэх бууруулсан төлөвлөгөө хүртэл биелүүлээгүй гэж ширүүн зэмлүүлсэн билээ. Уул нь төлөвлөгөө бууруулсан юм огт байсангүй. Тарианы төрөл зүйлээр ердийн тодруулга хийж, нэгнийх нь төлөвлөгөөг бууруулж, нөгөөгийнхийг нь нэмсэн хэрэг, гэвч Сталин хөдөө аж ахуйг мэдэхгүй, энэ мэт ажлын нарийн учрыг төдийлөн олдоггүй хүн. Түүнээс гадна Ленинград мужийн хувьд зургадугаар сар бол бэлтгэлийн шийдвэрлэх сар хараахан биш учраас чухамдаа ямар ч тасалдал гараагүй байсан юм. Гэвч Киров тогтоолыг эсэргүүцээгүй. Нам тасалбарын системийг халах бэлтгэл хийж байхад улс орныг талх, тариагаар хангах ажилд бүх хүчээ төвлөрүүлж бүгдийг шахаж шавдуулах хэрэгтэй, тийм учраас ташуурын амт үзүүлэхдээ хүрвэл мэдээж тэргүүлэх намын байгууллагыг жишээ болгосон нь дээр, тэгвээс сая бусдад сайхан сануулга болно. Энэ бол ердийн хэрэг, Киров ч өөрийнх нь эсрэг чиглэсэн ямар нэг муу юм үүнээс олж харсангүй. Уул нь Москвагийн намын байгууллагаар жишээ авсан бол улам л илүү ашигтай байх байсан юм. Яагаад гэвэл дутагдал нь ижилхэн байгаа, харин эндхийн бэлтгэлийн хугацаа түрүүлж эхэлнэ. Гэтэл Москвагийн намын байгууллагыг Каганович толгойлдог, Сталин чухамдаа түүнд халдахыг хүсэхгүй байгаа юм. Нэгийг нь гомдоож, нөгөөг нь урамшуулж, хооронд нь яс хаях явдал бол Сталины ашиг завшаан хайсан тод шинж. Степан Шаумян дээр үед нэг удаа “Коба могой шиг зан араншинтай” гэж хэлж билээ. Гэвч Киров үүнийг юу гэж тоох билээ. Намын ажил хэрэг шийдэж байхад хувийн гомдол санал гэж байх ёсгүй. Энэ бүхний хажууд Киров Кагановичийг жигшин үздэг билээ. Ямар ч байлаа гэсэн Ленинград хоцорч байгаа тухай Төв Хорооны зургадугаар сарын шийдвэр Кировг ойлгомжтой байсан бол Казахстанд үр тариа бэлтгэх тухай яриа ойлгомжгүй байв. Мань хүн түүхийн сурах бичиг бүтээх ажилд оролцоно гэдэг бол хуурамч зүйл, тэрээр ямар юмных нь түүхч байх вэ дээ! Сталин ч бас түүхч биш, гэтэл тэрээр өөрийгөө түүхч гэж үзэж байна. Ингэхэд өөрийг нь чухам яах гэж дуудав аа?

–За тэр ч яахав, бид нар чинь яагаад гэнэтхэн ургацын тухай, Казахстаны тухай, Мирзояны тухай яриад эхлэв дээ? хэмээн Сталин цочирхон өгүүлснээ, –Бидэнд энд нэг ажил байна, тэр бол түүхийн асуудал гээд Жданов руу харж, –Та Сергей Мироновичид байдлыг танилцуулсан биз дээ? гэж асуув.

–Танилцуулсан. Урьдчилсан байдлаар гэж Жданов хариулав.

–Түүхийн шинжлэх ухааныг гартаа авах хэрэгтэй байна, эс тэгвэл бусдын гарт, хөрөнгөтний түүхчдийн гарт орчихно, тэгж яривал манай түүхчид ч тэднээс дээрдэх юм алга. Покровскийн тухай бол бүр ярих юм алга, тэр нөхөр чухамдаа бас л хөрөнгөтний түүхч гэж Сталин царай нь хөрзийн өгүүлэв.

–Покровскийд алдаа байсан нь гарцаагүй, гэхдээ Ленин түүнийг өөрөөр үнэлж байсан... гэж Киров зөрөв.

Сталин Кировыг сонжсон янзтай харсан чигээрээ,

–Ленин түүнийг юу гэж үнэлж байсан юм бэ? гэв.

–Покровскийн “Оросын түүхийн маш хураангуй найрууллын” талаар Лениний түүнд бичсэн захидлыг бодвол та мэдэх байлгүй?

–Покровскийд юу бичсэн билээ?

Ленин Покровскийд юу бичсэнийг Сталин мэднэ шүү дээ, зүгээр ч үгүй сайн мэднэ, гэхдээ зөрүүтэй хэлбэл түүнийг нь ашиглах гэж байгаа хэрэг.

–Би яг үгчлэн санахгүй байна... Тэр захидал олон удаа хэвлэгдсэн юм чинь харж болох юм. Ямар ч байсан Ленин түүний амжилтад баяр хүргэж уг ном өөрт нь гойд сайхан санагдсан, гадаад хэл рүү орчуулах хэрэгтэй гэж бичсэн.

–Тийм ээ, Ленин тийм магтаалын үг хайрласан, тийм явдал байсан хэмээн Сталин зөвшөөрөөд, — Гэхдээ хөнгөн хуумгай байлгахгүйн тулд уг номд он цагийн хэлхээс нэмэх санал тэр дор нь тавьсан юм... Чухамхүү энэ анхааруулга бол Лениний үнэлгээний гол сүнс мөн... гэв.

–Би түүхч биш гэхдээ тэгж бодохгүй байна гэж Киров хэлээд, — Ерөнхий үнэлгээ нь оновчтой тодорхой бөгөөд сайшаасан үнэлгээ байсан. Он цагийн хэлхээс нэмэх санал бол бүхэлд нь сайшаасан үнэлгээг үгүйсгэж чадахгүй зүгээр нэг тухайлсан нэмэлт төдий зүйл. Покровский тэр номоо 1920 онд бичсэн, түүний ном бол чухамдаа Оросын түүхийг марксизм ленинизмийн байр сууринаас тайлбарлах гэсэн анхны оролдлого. Тэгээд ч өргөн олон түмэнд зориулсан энэ номыг Покровский Лениний даалгавраар бичсэн юм. Янз бүрийн алдаа байлаа ч гэсэн энэ бол ихээхэн чансаатай бүтээл, бид нар түүгээр л суралцсан. Мэдээж, шинжлэх ухаан урагшлан хөгжсөн, одоо шинэ сурах бичиг хэрэгтэй байж магадгүй, гэхдээ зарим нэг түүхчид шиг Покровскийн бүтээлийг муулах нь буруу, сүүлийн жилүүдэд түүнийг хавчиж байгаа шиг хяхаж хавчих нь байж болшгүй зүйл, Покровский шударга хүн байсан нь эргэлзээгүй... гэв.

–За тэр харахгүй юу, ийм байж түүх мэддэггүй гэж яриад байгаа шүү хэмээн Сталин жумалзаж, — Чи түүхээр биднийг бүгдийг нь давчихаад байна. Чиний хэлдэг ч зүйтэй, түүхийн шинэ сурах бичиг бүтээх хэрэгтэй. Чухам үүний тулд л чамайг нааш нь урьсан юм, чи ирэх дургүй байсан, гэтэл энд хэрэгтэй хүн чинь яг чи л байсан байна шүү дээ. Гэхдээ одоо бол Покровскийн тухай ярьж байгаа юм биш. Би намын зарим гишүүн, намын ахмад гишүүдийн тухай ярьж байна. Жишээ нь, нөхөр Надежда Константиновна бас түүхээр ажиллаад эхэллээ. Түүний Лениний тухай дурдатгалыг чи уншив уу? гэв.

–Уншсан гэж Киров толгой дохив.

–Тэгвэл энэ дурдатгалын талаар Поспеловын “Правдад” бичсэн өгүүллийг?

–Бас уншсан.

–Ажил хэрэгч сайн өгүүлэл хэмээгээд Сталин эргэж явган ширээн дээрээс хавтсаа авч дотроос нь “Правда” сонины хайлчилбарыг олж улаан будгийн харандаагаар таслан зурсан хэсгүүдийг гүйлгэн харснаа, — За, энэ... Поспелов ингэж бичсэн байна. “Крупская Плехановын манай намын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг шүүмжлэлгүй хандан хэтрүүлж, харин Ленинийг Плехановын элбэрэлт шавь мэтээр дүрсэлсэн байна”. Зүйтэй санаа. Яагаад зүйтэй гэж байна? Яагаад гэвэл Крупская эдгээр зүтгэлтнийг эрт дээр үеийн нүдээр харж байна, харин Поспелов бол өнөөдрийн нүдээр харж байна. Тэгэхлээр бид хэдийгээр Плехановыг хүндэтгэдэг, түүний үйл ажиллагааг өндөр үнэлдэг ч гэсэн өнөөдрийн туршлагыг үндэс болгон одоо энэ хоёр зүтгэлтнийг зэрэгцүүлж тавьж чадахгүй юм гэв.

Киров Сталиныг чих тавин сонссоор байв. Түүний санаанд Поспеловын өгүүлэл тодхон байгаа. Хэргийн учир Плехановт падгүй нь мэдээж. Нарийн учир нь Крупскаягийн дараах үгэнд байгаа юм. “Хуучин нууц байдлаас болоод далайцтай ажиллах боломжгүй байсан хүмүүс Октябрийн дараагаар тэргүүн байранд дэвшин гарч ирэх болсон юм... Тийм хүмүүсийн тоонд нөхөр Сталин хамаарч байлаа”. Энэ хэдэн мөр Сталины уурыг яаж шатаана гэдгийг Киров тов тодхон төсөөлөхийн хамт маш түргэн хариу өгнө гэж ойлгож байжээ. Яг тийм болж таарсан. Поспелов “Правдад” урт өгүүлэл хариу болгон бичиж зөвхөн нэг гол үндэслэлийг гаргахын тулд дурдатгалын янз янзын санааг шүүмжилсэн байсан юм. Тэр үндэслэл нь энэ: “Сталин, Свердлов нар шиг намын удирдагчид - нэр хүндтэй зохион байгуулагчид нууц байдлын үед ч гэсэн тэргүүлэх үүрэгтэй байсан нь хилийн чанадад биш яг Орос дотроо ажиллаж байсан үндсэн большевик боловсон хүчнүүдэд тов тодорхой байсан билээ”. Энэ мэдээж, тийм биш. Гэвч Сталин, бүр хувьсгалаас өмнө намын дотор хоёр дахь хүн нь Сталин байсан, Ленин намыг хилийн чанадаас удирдаж байсан, харин Сталин бол Орос дотроосоо удирдаж байсан гэдэг үндэслэлд өчүүхэн төдий ч халдахыг тэсвэрлэдэггүй билээ. Энэ нь хэдийгээр үнэнд эс нийцэвч нам шинэ удирдлагаа хүрээлэн нягтрахад тус дөхөм болж байсан учир Киров тэр үндэслэлийг хүлээж авсан юм. Гэхдээ аль нэг үндэслэлийг улс төрийн шаардлагын үүднээс хүлээж авах нэг хэрэг, харин түүнд чин санаанаасаа итгэнэ гэдэг бол өөр хэрэг. Сталин тамшаалав.

–Цөмөөрөө дурдатгал бичих гэдэг болцгоолоо. Үгүй, тэр Авель Енукизег бас харахгүй юу.

Сталин дахиж явган ширээ рүү эргэж, мөн нөгөө хавтаснаасаа Енукизегийн товхимлыг гаргаж ирээд Кировт үзүүлж,

–Уншсан уу? гэв.

Киров Енукизегийн товхимлыг уншсан, түүнээс юу нь Сталины санаанд нийцэхгүй байгааг ойлгож байжээ. Тэрээр уншаагүй гэж хэлээд ярианаас зайлдаг ч юм билүү гэсэн санаа хэсэгхэн зуур толгойд нь эргэлдэв. Гэвч тэгэх юм бол Сталин уншиж үз гэж хэлэх учраас тэртэй тэргүй энэ тухай ярианаас мултрахгүй.

–Тэгсэн... гүйлгэж харж байсан... Гарт тааралдаж л байсан юм байна...

Булзааруулсхийн хариулж байгааг Сталин ойлгов.

–“Тааралдаж л байсан”, “гүйлгэж харж байсан” хэмээн Сталин давгаж хэлээд, –За тэгвэл энэ товхимлоос үзэх юм бол “Нина” хэвлэх үйлдвэрийн тухай зөвхөн гуравхан хүн мэдэж байсан болж таарах гэж байна. Красин, Енукизе, Кецховели гурав. Авель Енукизе үүнийг яаж мэдэв вэ? гэв.

–Тэр чинь хэвлэх үйлдвэрийн нэг удирдагч байсан.

–“Нэг удирдагч...” гэдэг чинь яг. Бас Красин, Кецховели хоёр байсан. Тэгээд Кецховели тэр үйлдвэрийн үйл ажиллагааг надаас нуудаггүй байсан юм. Гэвч Красин, Кецховели хоёр насан өөд болцгоосон. Амьд сэрүүн байгаа нь ганцхан Авель Енукизе, гэхдээ тэр амьд байгаагаараа түрээ барьж хэвлэх үйлдвэрийн түүхийг жинхэнэ байснаар нь биш өөрийнхөө санаснаар зохиож байх эрх түүнд байхгүй.

–Таныг байдлыг мэдэж байсан гэдгийг Енукизе мэдэхгүй байсан бололтой. Бодвол Лениний удирдамж яв цав биелэгдэж байгаа гэж бат итгэлтэй байсан байх гэж Киров хэлэв.

–Ямар удирдамж хэмээн Сталин хэрдхийв.

–Хэвлэх үйлдвэрийн тухай Красин, Енукизе, Кецховели гурав, бас өрөгч нараас өөр хэн ч мэдэх ёсгүй гэсэн удирдамж.

–Чи тэр удирдамжийн тухай хаанаас мэдэв?

–Энэ ч нийтээр мэдэх баримт.

–“Нийтээр мэдэх” гэдэг чинь юу гэсэн үг вэ? Үүнийг Енукизе санаанаасаа зохиож, тэгээд цөмөөрөө үнэмшчихсэн байна. Хэвлэх үйлдвэр үнэхээр хилийн чанад дахь төвд захирагдаж байсан юм. Гэхдээ тэр үйлдвэрийн тухай намайг мэдэхгүй байсан гэж үзэх ямар үндэс байна? Үйлдвэрийг Ленин биечлэн удирдаж байсан нь үнэн, гэхдээ энэ бол Енукизегийн бичиж байгаачлан тэд нараас гадна тэр тухай мэдэх хүн нэг ч байгаагүй гэсэн үг огт биш. Хэрвээ нөхөр Енукизе үнэнхээсээ тэгж бодож байгаа юм бол энэ баримтыг тэр үед Бакуд байсан хүмүүсээс яагаад лавлаж шалгасангүй вэ? Бас яагаад үүнийг чухамхүү одоо гаргаж ирэв? Яагаад ганцхан зүйлийг онцлон цохож байна? Яагаад энэ бүхэн хэрэгтэй болов? Энэ бол намын удирдлагын залгамж чанарын тухай сэдвийг няцаах, Төв Хорооны өнөөгийн удирдлага Лениний шууд үе залгамжлагч биш, хувьсгалаас өмнө Ленин өнөөгийн намын удирдагчдаас өөр хүмүүсийг түшиглэж байсан, түүгээр ч барахгүй Ленин тэр хүмүүст итгэдэг, одоогийн удирдагчдад итгэдэггүй байсан гэж нотлохын тулд хэрэгтэй болсон байна. Нөхөр Енукизе хэний галд тос нэмж байна вэ?

–Нөхөр Енукизег тийм зорилго тавьсан гэж би бодохгүй байна хэмээн Киров зөрж, –Зүгээр л мэддэг юмаа бичсэн гэж бодож байна. Кецховели танд мэдээлдэг байсан тухай тэрээр мэдэхгүй байсан ч байж болно. Би яг тэгж итгэж байна гэв.

–Тэгж итгэх үндэс байгааг би харахгүй байна хэмээн Сталин хүйтэн өгүүлээд, –Тэгж бодох

үндэс байгааг ч харахгүй байна. Нөхөр Енукизе намд нэг өдөр болж байгаа хүн биш, нөхөр Енукизе бол намын Төв Хорооны гишүүн, нөхөр Енукизе хийж байгаа хэргийнхээ улс төрийн үр дагаврыг эргэцүүлж бодохгүй байх ёсгүй, нөхөр Енукизе түүний товхимол өнөөдөр хэний ашиг сонирхолд нийцэж байгааг ойлгохгүй байх ёсгүй. Хэрэв энэ товхимлыг ердийн нэгэн түүхч бичсэн бол тоохгүй өнгөрч болох байлаа. Яагаад гэвэл түүхчид алдаа гаргаж болно, түүхчид элдэв салангид баримтын эрхшээлд автах нь элбэг байдаг, түүхчид бол ёс шиг муу диалектикчид, арчаагүй улс төрийн бодлоготнууд байдаг юм. Гэтэл энэ товхимлыг жирийн нэгэн түүхч биш нам, улсын нэг удирдагч бичжээ. Ямар зорилготой бичив? Дурдатгал бичих дур нь хөдлөө юу? Тэр дур эртэдсэн байна. Нөхөр Енукизе бол одоохондоо залуу хүн, бид хоёр бараг чацуу, гэтэл би өөрийгөө өвгөн болсон гэж хараахан үзэхгүй, дурдатгал бичих гэж завдаагүй байна. Энэ бол дурдатгал биш улс төрийн үйлдэл. Манай намын түүхийг мушгин гуйвуулахад чиглэсэн үйлдэл, намын өнөөгийн удирдлагын нэр хүндийг гутаахад чиглэсэн үйлдэл. Нөхөр Енукизе ийм л зорилго өөртөө тавьсан байна гэв.

–Та арай хэтрүүлж байгаа болов уу гэж би бодож байна хэмээн Киров хөмсгөө зангидаж, – Енукизе түүхч ч биш, зохиолч ч биш юм чинь ийм товхимол бичих нь ерөөсөө түүний хийх ажил биш. Түүнийг намын удирдлагын нэр хүндийг гутаах гэж байна гэдэгт би бол эргэлзэж байна. Тэр чинь илэн далангүй, шударга хүн, таныг ч бас хайрлаж хүндэлдэг хүн гэв.

Сталин Кировыг духан дороосоо эгцлэн ширтэв. Нүд нь шар, барсных мэт ажээ. Уур нь дэврэн оросоор улам буруу дуудлагатайгаар,

–Шударга зан, илэн далангүй байдал, хайр хүндэтгэл гэдэг бол улс төрийн ухагдахуун биш. Улс төрийн бодлогод бол ганцхан зүйл байдаг юм. Тэр улс төрийн тооцоо.

Яриа яршигтай болох тийшээ хандлаа. Сүүлийн үед Сталинтай ярихад ер нь хэцүү болсон бөгөөд ялангуяа уцаар байх үед нь бол бүр ч бэрх.

–Нөхөр Енукизег залруулж түүхийн асуудлаар түүний мэдлэг учир дутагдалтай байгааг заан анхааруулж болно гэж Киров эвлэрэнгүй өчив.

–Тиймээ хэмээн Сталин түүний үгийг тосон авч, - Хэрэв энэ товхимлыг аль нэг түүхч бичсэн бол түүнийг тэр нэг түүх ч нь залруулж болохсон. Гэвч үүнийг Төв Хорооны гишүүн, манай орны нэг томоохон удирдагч биччихээд байна. Тэгэхлээр түүнийг мөн тийм зиндааны хүн залруулбал зохино гээд тэрээр Киров руу яг эгцлэн харах зуур, — Чи Бакугийн намын байгууллагыг таван жил толгойлсон, чиний бичсэн юм л хамгийн нэр хүндтэй байхсан гэж өгүүлэв.

Киров мэл гайхжээ. Ийм явдал хараахан тохиолдоогүй байгаа билээ. Сталин “Нина” хэвлэх үйлдвэрийн нэг удирдагч байсан гэдгийг Улс төрийн Товчооны гишүүн мань хүн нийтийн өмнө гэрчлэх ёстой болох нь. Гэтэл Сталин тийм үйлдвэр байсныг ч мэдэхгүй явган, тэр тухайд Енукизегийн бичсэн зүйл зөв. Яагаад өөрт нь ийм санал тавих болов? Өнгөн дээрээ дэмждэгийг шалгаж байна уу? Уул нь тэр талаар хангалттай шалгасан, харин дахиад шалгах хэрэгтэй бол үүнээс арай өөр жишээгээр шалгахаар даа.

–Би хэзээ ч түүхээр оролдож яваагүй, тэгээд ч энэ тодорхой асуудлын тухайд мэдэх юм огт

алга. Түүнээс гадна энд яригдаж байгаа цаг хугацааны хувьд бол би тэр үед Бакуд байгаагүй шүү дээ гэж Киров хэлэв.

–За тийм байж, мэдэхгүй гэдэг үг мянган үгийн хариу гэдэг дээ хэмээн Сталин тайван өгүүлээд, –Авель Енукизед хариу өгөх чадвартай нөхөд манай намаас олдоно гэж найдаж байна гэснээ, Жданов руу эргэж, –Энэ асуудлыг Төв Хороо хөөцөлдөх хэрэггүй юм. Энэ бол бүх намынх биш, зөвхөн түүний нэг байгууллага, өвөр Кавказын намын байгууллагын асуудал. Тэгэхээр өвөр Кавказын намын байгууллага л өөрийнхөө түүхийн учрыг олно биз. Нөхөр Берияг дуудаад түүнд Төв Хорооны үзэл бодлыг танилцуулаарай. Тэр өвөр Кавказын хязгаарын намын хорооны нарийн бичгийн дарга юм чинь энэ бол түүний эрх мэдлийн асуудал гэв.

Маргааш өглөө нь Сталин хоолныхоо дараа эмч дуудуулах тушаал буулгав.

Липман чемодантайгаа ирж багаж хэрэгслээ дэлгэн түмпэн зэхэж тавиад Сталиныг сандал дээр суулгаж хоолойгоор нь алчуур зангидлаа.

–Хэр зэрэг унтаж амрав? гэж Сталин сонирхов.

–Маш сайхан амарлаа, анир чимээгүй, намуун тайван оргиод энэнээс сайхан гэж яаж байх вэ хэмээн хариулах зуур Липман шприцэндээ эм соруулан Сталины толгойг түшүүр дээр аятайхан дэрлүүлж, амаа ангайхыг хүсээд, -Бусад хүнд ямар байдгийг мэдэхгүй юм, надад бол далайн түрлэгийн шуугиан дандаа бүүвэйн дуу шиг сайхан байдаг юм... гэв.

Сталинд тэгж санагдсан юм уу, эсвэл үнэхээр тэгсэн юм уу буйл руу нь зөөлхөн тарьчих шиг болов. Липманы царайгаар юмны баримжаа авах арга алга, мань хүн нөгөө л инээмсэглэсэн чигээрээ ам руу нь харж байв. Тэгснээ арагшаа налж хоёр гараа өвдөг дээрээ тавиад аанай л инээмсэглэсэн хэвээр,

–Жаахан суузцагаая, наркоз үйлчлэг. Та амаа хамхиж болно, юм ярьж болно, босоод жаахан явсан ч болно, гэхдээ суузнаж байсан нь дээр гэж хэлэв.

Буйланд нь ямар нэг юм дүүргэж байх мэт мэдээ алдран бадайрах ажээ. Сталинд урьд өмнө нь мөн хэсэгчилсэн наркоз хийж шүдийг нь авч байсан боловч наркоз үйлчилтэл хэр удаан хүлээх хэрэгтэйг тэрээр санахгүй байв. Тэгээд,

–Удаан хүлээх шаардлагатай юу? гэж асуув.

–Арваад минут болов уу гэж бодож байна. Амаа дахиад ангай даа, би нэг хараад орхиё.

Тэрээр амыг нь дахин шалгаж хараад нэг төмөр багажаар буйлан дээгүүр нь гүйлгэж үзэв.

–Мөдхөн жиндчихнэ, жаахан тэвчээрэй.

Мань хүн тариагаа өвтгөлгүй эвлэгхэн хийсэн учир нөхөр Сталин өөрийг нь үнэлж байгаа хэмээн түүнийг ивээх мэт тогтуухан харж суув.

Ажлаа сайн мэддэг, сайн хийж чаддаг хүмүүсийг Сталин үнэхээр үнэлдэг билээ. Энэ эмч ажил, амьдрал, байр байдлаараа сэтгэл хангалуун байдаг юм байна, бодвол зуу наслах байлгүй. Кремльд ажил хийж байна, Улс төрийн Товчооны гишүүдийг эмчилж байна, бодвол аятайхан хувь авдаг байх, агаархах хүмүүс гарна даа, агаархагчид хэзээ ч олдоно. Гэхдээ энэ эмч атаа жөтөөг тоодоггүй бололтой. Хорвоогийн дийлэнх олонхийн адил нэр алдар, эрх тушаал горилдоггүй хүн байна. МАНЬ ХҮН дээр үед бүр залуухан байхдаа чухамхүү ийм хүмүүсийн төлөөнөө тэмцэж эхэлсэн, гэхдээ тэмцлийнхээ бусад учир шалтгааныг хожим ойлгосон юм. Гэтэл МАНЬ ХҮН одоо ийм хүмүүсийг удирдан жолоодож, цаадуул нь өөрийг нь бурхан мэт итгэн сүсэглэж байгаа, бурханд бол гагцхүү бодох санах юмгүй ухаан жолоогүй

бишрэн шүтэж болно, эд нар ӨӨРИЙГ нь эцэг гэгцгээдэг, хүмүүс эцгийн хатуу чанд бөгөөд чанга найдвартай гарыг хүндэлдэг. Энэ нөхөр гэхэд л зөвхөн ТҮҮНИЙГ шүргэдэг гэж бодохоос үхэр нохой мэт үнэнч байгаа, өөрийнх нь эргэн тойронд ийм хүмүүс бас заавал байх ёстой. Зөвхөн гарз ноход шиг хамгаалагч нар, нэр алдар хөөсөн туслахууд төдийгүй, ТҮҮНИЙГ хайрладаг, ТҮҮНД үнэнч энгийн номхон даруу хүмүүс байх ёстой.

Липман дэргэд нь суугаад Сталин руу инээмсэглэн цагаа хаа нэгтээ харж, заримдаа амаа ангайхыг гуйж, ямар нэгэн багажаар буйлан дээгүүр нь явуулж үзэх бөгөөд нэг тэгж үзсэнийхээ дараа суга татсан шүдээ хазууртай чигээр нь Сталинд үзүүлэв. Та чинь хэдийд нь амжуулчихав аа?! Би бүүр юу ч мэдэрсэнгүй.

–Би наркотай авлаа шүү дээ. Тэгээд ч энэ шүд дөнгөж тогтох төдий, бид нарын хэлдгээр бол хуруугаараа авчихаар байсан юм.

–Тэгээд авчихгүй яасан юм бэ?

–Тэгсэн бол ч та мэдрэх байсан шүү.

Сталин тоссон түмпэн руу цустай зунгаарсан урт шулсээ нулимснаа амаа нэгэнтээ зайлаад дахин нулимав.

Липман Сталинд шинэ алчуур өгч амыг нь арчуулаад,

–Хоёр цаг юм битгий идээрэй, ер нь өнөөдөр халуун хоол идэх хэрэггүй гэв.

Тэгээд ширээн дээрээс хэлхээ хиймэл шүдийг авч гартаа эргэлдүүлснээ,

–Сайн шүд байна, хийц нь ч сайн юм, бас алт, цагаан алт, палладий гурвын хайлшаар хийсэн онцгой сайн материалтай юм. Одоо ч энүүний хэрэг байхгүй ээ, танд шинийг хийж өгнө. Харин Иосиф Виссарионович оо, ердийн хиймэл шүд хийвэл дээр баймаар ч юм шиг гэв.

–Ердийн гэдэг чинь юу гэсэн үг вэ?

–Энэ чинь бол шүднүүдээ хооронд нь төмөрлөгөөр бэхэлсэн байна, харж байгаа биз дээ, харин одоо нийтэд нь хуванцраар хийчихнэ.

–Тэгэх ямар хэрэг байна?

–Иосиф Виссарионович, ийм юм л даа, төмөрлөгтэй хэлхээ шүд бол энэ хоёр дэгээгээрээ бэхлэгдэнэ, бид нар энэ дэгээг кламмер гэдэг юм. Шүдний хэлхээ хөнгөн байх үед шүдэнд ч бас хөнгөн байдаг юм. Гэтэл таны энэ хэлхээ хэдийн долоон хиймэл шүдтэй болчихсон байна, энэ бол хүнддэнэ, дэндүү хүнддэнэ. Одоо шинээр хийхдээ бас нэг шүд нэмнэ, хэлхээ улам хүнд болж, дэгээний ачаалал бас нэмэгдэнэ. Харин хавтгай суурьтай хиймэл шүд бол тагнайд хөхөгдөөд хичнээн ч шүд хийсэн даадаг юм.

–Та надад хөгшчүүлийн шүд хийх нь ээ дээ.

–Яагаад хөгшчүүлийнх байх билээ? Хөгшчүүлд шүд байхгүй юм чинь тэдэн бүтэн эрүү шүд хийдэг юм, танд бол өөрийн чинь шүд байна шүү дээ. Эд чинь зөндөө удна, тэнгэр тэтгэх болтугай.

Хэдэн жилийн өмнө Сталин хэдэн араг авч анх удаа хиймэл шүд хийхийг санал болгоход мань хүн ингээд дуусдаг байжээ, хиймэл эрүүтэй өвгөн боллоо хэмээн гутарч гүйцсэн билээ. Тэрээр өвөгчүүл шөнө унтахдаа хиймэл шүдээ сугалан авч аягатай усанд хийдгийг үзсэн юм. Сольц тэр хоёр Петербургт нууц байранд цуг аж төрдөг байхад чухам түүнээс анх удаагаа хиймэл эрүүг харсан, тэр үед нас өвгөрөх яагаа ч үгүй асан Сольц хиймэл шүдээ шөнө тэгж авдаг байсан билээ. Сольц юм ярихдаа дандаа тэвдэнэ, тэгээд ярихтайгаа зэрэг нөгөө хиймэл эрүү шүд нь мултран гарч мань хүн түүнийгээ хэлээрээ тогтоон эвлүүлэх гэж оролдоход үг нь мэдэгдэхгүй тультран харахад түн зэвүүн сэн.

Гэвч эмч нар тэгэхэд хиймэл эрүү хийхгүй, харин алтан хуудсан дээр хиймэл араануудыг бэхэлж тогтооно, тэгэхлээр хоол зажлах юмтай болно гэж тайлбарлаж өгчээ. Тийнхүү алтан хуудас тааруулж, мань хүн ч түүндээ дасаж, тэр нь эвгүй оргиж саад болохгүй, шүдгүй гэж мэдэгддэггүй болчихсон юм. Хожим дахин хоёр шүд авч Липманы саяын хэлж байгаа шиг тагнайтай шүд хийхийг санал болгож мөн түүний ярьж байгаа шиг учир шалтгааныг тайлбарлахад мань хүн таггалзаж, тийнхүү Липманы одоо барьж байгаа алтан хэлхээ шүдийг хийлгэсэн юм. Энэ шүд нь элдэв яриаг эс харгалзан эзэндээ тун сайн үйлчилж байгаа билээ.

Липман одоо өвөгчүүлийн шүд хийлгэхийг санал болгож байна. Липман богино жолоотой хүн юм, өөрийг нь зөвхөн эмчлүүлж байгаа хүн төдийд үзээд энэ өвчтөнийг нь сая сая хүн ширтэн харж байдаг, тэгэхлээр тэдний нүүрэн дээр мултарч унаад байдаг эрүү шүдтэй гарч ирж болохгүй, амандаа агшаасан будаа үмхсэн мэт тультран шулганаж болохгүй гэдгийг мартаад байна.

–Алтан шүд хийчих гэж Сталин хэлэв. Липман дахин зөрж зүрхэлсэнгүй.

–За, мэдлээ. Шүдний ором өвдөх янзтай байвал нэг үрэл пирамидон уучихаарай, шаардлагатай бол намайг дуудуулаарай. Эдгэж байгаа явцыг маргааш харж болно биз дээ.

–Маргааш энэ үед таныг урина.

Липман явлаа. Сталин толь руу очиж амаа ангайгаад шүдээ гаргалаа... Дээд талд нь дөнгөж тавхан шүд хоцорчээ, тамхинд нэвчсэн шар шүднүүд, харахаас ой гутам... Зүгээр, Жданов түүнийг тавхан шүдтэй ч гэсэн хэдэн өдөртөө тэвчиж чадна. Киров ч бас тэвчинэ.

Кировын тухай бодонгуут Сталин ярвайн үрчийв. Тэмцэлд оролцохгүй, намын удирдлагыг бэхжүүлэхгүй санаатай байна гээч!

Наркозны хор гарч, шүдний ором аньж эхлэг хэмээн Сталин энэ өдөр хэнийг ч хүлээж авсангүй. Эмчийн заасан ёсоор хоёр цаг юу ч амссангүй, үдийн хоолонд хүрэн манжингийн хүйтэн шөл, зөөгтсөн котлет өгсөн нь зажлах юмгүй хүнд тун зөв хоол байжээ. Шүдний ором, буйлны аль нь ч өвдөөгүй учир пирамидон уух хэрэг гарсангүй.

Өглөө нь Липман ирж амыг нь шалгаж үзээд,

–Тун сайхан эдгэж байна, хоёр хоногоос эхэлнэ ээ гэж сэтгэл хангалуун өгүүлэв.

–Яаж амарч байна? Уйдаагүй биз гэж Сталин асуув.

–Хаанаас даа, Иосиф Виссарионович оо, уйдаж байх цаг хаана байх вэ? Шумбах тэнгис, нарлах хөвөө хаяанд байж байна, бас үзтэл бичгийн ширээн дээр цаас, үзүүрлэсэн харандаанууд байж байна, юмаа бичээд эхэлсэн гэж байгаа.

–Та чинь юу бичдэг билээ?

–Хиймэл шүдний талаар тусгай ажил.

–Амжилт хүсье.

Шүднээсээ болоод нийтийн ширээ рүү очмооргүй байсан тул Сталин өдөр, оройныхоо хоолыг ганцаараа идэв. Гэвч ажиллах хэрэгтэй. Орой нь Жданов, Киров хоёр түүн дээр ирцгээлээ. Тэд нар сонин харцгаасан шиг сэрүүвчинд сууцгаав.

–За ингээд Гитлер бүх насаараа германы ард түмний фюрер, эзэнт улсын рейхсканцлер болжээ.

–Аягүй бол өөрийгөө эзэн хаанаар зарлах вий гээд Киров инээд алдав.

–Тэр ч тийм тэнэг юм хийхгүй ээ гэж Жданов хэлэв.

–Тийм шүү хэмээн Сталин санал нийлж, –Эзэн хаан өдий төдий байсан, харин нэг насны фюрер цорын ганцхан байгаа болохоор тэгж зарлах нь утга байхгүй. Түүнээс гадна түүнд хүүхэд байхгүй болохоор үе залгамжилсан хаад бий болгож чадахгүй... гээд сонины хуудсыг гүйлгэн харах зуур, –Нөгөө Зиновьев чинь дахиад л нэг өгүүлэл тургичихсан байна, өдөр болгон бичих юм. Ямар ч сонин нээсэн Зиновьев, Каменев, Радек энэ тэртэй заавал тааралдана гээч. Бичээд л байх юм, бичээд л байх юм... гэв.

–Хийх юмгүй болоод л бичицгээж байхгүй юу гэж Жданов өчив.

–Гэтэл юу нь сонирхолтой байна гээч хэмээн Сталин яриаг үргэлжлүүлж, — Өгүүлэл болгонд нөхөр Сталин тийм, нөхөр Сталин ийм, аугаа их хүн, суу билэгт хүн, мэргэн цэцэн хүн, бараг л Маркс, Энгельс, Ленинээс дээр гэх нь халаг нөхөр Сталиныг шагшин магтсан байх юм. Яах гэж шагшин магтаж байна вэ? Зиновьев нөхөр Сталиныг үнэн санаанаасаа магтаж чадна гэж үү? Чадахгүй. Тэр чинь нөхөр Сталиныг үзэн ядаж байгаа. Тэгэхлээр худлаа ярьж байгаа хэрэг, бодсоноосоо өөр юм бичиж байгаа хэрэг. Яах гэж худлаа бичиж байна? Уул нь түүнийг хэн ч үнэмшихгүй, нөхөр Сталин ч гэсэн үнэмшихгүй гэдгийг сайн ойлгож байгаа шүү дээ. Айж байгаа хэрэг үү? Хэнээс айж байгаа юм бол түүнийг хэн ч хөндөхгүй байгаа шүү дээ гэв.

–Зэвсгээ хурааж устгасан, одоо ямар ч юмны төлөө өрсөлдөхгүй гэж нотлох санаатай байна

гэж Киров хэлэв.

–Тэгж саная. Эргэлзээтэй л зүйл, гэвч тэгж саная хэмээн Сталин түүний үгийг зөвшөөрөөд, – Гэхдээ тэр өөрийгөө доромжилж байна. Гэтэл өөрийгөө доромжилсон хэн боловч түүнийгээ хэзээ ч мартдаггүй юм. Басамжлах, гомдоох, шударга бусаар хандах гэхчлэн юуг ч мартаж болно, харин доромжлолыг нэг ч хүн мартахгүй, энэ бол хүний мах цусны шинж. Адгуус араатан бол хоорондоо хөөлцөнө, уралцана, алалцана, идэлцэнэ, гэхдээ нэг нэгийгээ доромжилно гэж байхгүй. Гагцхүү хүн л бие биесээ доромжилно. Тэгээд өөрийнхөө доромжлуулсныг нэг ч хүн мартахгүй, доромжилсон хүнээ хэзээ ч өршөөхгүй. Харин ч болбоос үүрд үзэн ядна. Тэгэхлээр Зиновьев Сталиныг хичнээн их шагшин магтана, түүний өмнө өөрийгөө хичнээн их доромжилно, нөхөр Сталиныг төдийчинээ их үзэн ядах болно. Радек бас сүйд майд болж, бас шагшин магтаж байна. Радек чалчаа, болчимгүй этгээд. Өчигдөр Троцкийг шагшин магтаж байсан, өнөөдөр Сталиныг, маргааш хэрвээ шаардлага гарвал Гитлерийг магтан сайшаах хүн. Тийм хүнд гашуун гичтэй талхан зууш өгөхөд хавхийтэл үмхэж хэл амаа долоочихоод нэмэрт нь гялайлаа гэж хэлэх вий. Харин Зиновьев, Каменев хоёр бол тэгэхгүй, тэр хоёрын санаархал өөр, бүх насаараа жолоодогч болох гэж анасан, одоо ч анаж яваа улс. Тэдний талынхан нэмэгдэл хүчтэй болсон юм чинь бүр ч анаж байгаа. Бухарин бас Рыков өөрийнхөө бүлэгтэй тийшээ нийлсэн гэв. Киров дал мөрөө хавчив.

–Зиновьев, Бухарин хоёрт ямар холбоо байх вэ?

–Сергей Миронович минь, Бухарин Каменевтэй холбоо тогтоох санаатай арын хаалгаар нь гүйгээд байсан шүү дээ гэж Жданов зөөлхөн өгүүлэв.

Жданов Кировын сэтгэлд нийцдэг ч гэсэн Улс төрийн Товчооны гишүүд зөвхөн хоорондоо хэлэлцэх асуудал гэж бас бий. Жданов бол Улс төрийн Товчооны гишүүн биш. Сталин Киров, Жданов хоёрыг ялгаагүй гэж үзэж байгаагаа харуулахын тулд зориуд Ждановын дэргэд ийм яриа сэдлээ.

–Нөхөр Жданов, энэ чинь найман жилийн өмнө намын удирдлага тогтворжоогүй, Зиновьев, Каменев хоёр засгийн толгойд гарах гэж өрсөлдөж байх үеийн явдал шүү дээ. Тэд нар одоо өөрсдөд нь ямар ч горьдлого байхгүй гэдгийг сайн ойлгож байгаа, нэрээ нэгэнт хорлосон, олон жил гэмээ наманчилж байгааг ч бодсон, ялагдлаа хүлээж байдалтайгаа эвлэрцгээсэн, одоо ямар нэгэн найдвар, тооцоо тэдэнд огт байхгүй гэж би бодож байна хэмээн Киров зөрөв.

Жданов хариу хэлэх гэсэн боловч Сталин гар дохиж болиулаад,

–Улс төрийн бодлоготнууд бол засгийн төлөө байнга өрсөлдөнө. Тэгээд хичнээн их доромжлол хүлээнэ, тэр доромжлолынхоо өшөөг авна гэж төдийчинээ их найдна. Тэд доромжлуулсан хүнээ хэзээ ч өршөөхгүй, ялангуяа чи бид хоёрыг өршөөнө гэж бүр ч хол хэвтэнэ. Зиновьев Ленинградыг өөрийн эзэмшил нутаг гэж үзэж байсан. Арван дөрөвдүгээр их хурлын өмнө Ленинградын намын байгууллага Зиновьевын төлөө, намын эсрэг санал өгч байсан. Харин одоо бол нөхөр Киров Ленинградын намын байгууллагыг даруй найман жил толгойлж, Ленинградын намын байгууллага ч нөхөр Кировыг дагаж байна. Ленинградын намын байгууллага Зиновьевыг аль хэдийн мэдэхээ больсон, одоо зөвхөн Кировыг л мэдэж

байгаа. Зиновьев үүнийг чамд өршөөх үү? Үгүй ээ, өршөөхгүй. Тэгээд анхны боломж гарсан даруйд өшөө авна гэв.

–Та ойлгогдохгүй юм ярьж байна гэж Киров дал мөрөө хавчаад –Тэд ямар аргаар, хэний гараар, яаж надаас өшөөгөө авах гэж байгааг би ойлгох ч үгүй, харах ч үгүй, гадарлах ч үгүй байна.

–Гар хэзээ ч олдоно, ийм ажилд гар хэзээ ч олддог юм. Ленинградад бол бүр ч элбэг олдоно. Тэнд зиновьевчуудын ёзоор их бий, чи тэр ёзооруудыг суга татаж хаяхыг хүсэхгүй байна, тэр зэвсгээ хураалгасан царайлаад гэмшсэн царайлаад байгаа хүмүүст итгэсээр байна гэж Сталин өчив.

Тэрээр Киров руу эгцлэн ширтэнэ. Нүд нь хүнийх юм шиг, нүүр нь бөөн нөсөө. Нөсөө ямар ч гэсэн хүний царайг эвддэг юм байна. Тэгж бодохоос дотор хачин оргив. Уул нь нөсөө ямар хамаа байх вэ дээ! гэж бодогдмоор. Гэтэл хачин оргиод л байна даа! Кировын нөсөөг хараад өөрөө бас хоосонгүй гэдгээ саналаа.

–Нөхөр Сталин хэмээн Киров эрсхэн өгүүлж, –Хорин таван онд Ленинградын намын байгууллага Зиновьевын төлөө санал өгч байсан. Гэтэл хорин зургаан он гэхэд л бидний төлөө, Төв Хорооны төлөө саналаа өгсөн. Эд бол намын жирийн гишүүд. Хорин таван онд намын удирдлагууд дээрээсээ аваад доороо хүртэл Ленинградын удирдлагын төлөө саналаа өгөхийг тэдэнд ятгаж, ятгах ч юу байх вэ дээ, шулуухан хэлэхэд тэгж тушааж байсан юм. Саналаа өгөхгүй байна гэдэг нь намын сахилгыг зөрчсөн хэрэг болох гээд байж л дээ. Харамсалтай нь төвлөн удирдах ардчилсан зарчмын уршиг тэр. Намын аль ч байгууллага удирдлагаа дагаад алдаатай замаар нэг хэсэгтээ явчихаж мэднэ. Намын жирийн гишүүд үүнд буруу байхгүй, тэглээ гэж тэднийг шийтгэх эрх ч бидэнд байхгүй гэв.

–“Намын жирийн гишүүд” хэмээн Сталин хямсайж, –хэрвээ районы намын хорооны нарийн бичгийн дарга тэднийг намын эсрэг, түүний Төв Хорооны эсрэг босгож чадаж байгаа юм бол тэд нар ч намын муухан гишүүд байх вий. Ленинградын коммунистууд бол чиний бидэнд одоо яриад байгаа шиг тийм ч хээгүй амьтад биш. Тэд нар чинь одоо хүртэл өөрийнхөө хотыг хувьсгалын өлгий, өөрсдийгөө оросын ажилчин ангийн манлай гэж үзсээр байгаа шүү дээ. Өөр нэг юм байна. Ленинградад чинь намын сахилгын журмаар санал өгсөн хүмүүс төдийгүй тэднийг саналаа өгөхийг албадаж байгаа хүмүүс ч бас үлдсэн байгаа. Тэд нар бас л гэмшигчдийн тоонд яваа, гэтэл тэдний гэмшил бол Зиновьев, Каменев энэ тэрийн гэмшлээс ялгарах юм ор байхгүй, өөрсдийнхөө цагийг хүлээж намын дотор, улс орны дотор өчүүхэн төдий үймээн үүсэхэд л тэр цаг нь хүрээд ирж мэднэ гэдгийг ойлгож байгаа. Намайг, чамайг, бас Улс төрийн Товчооны өөр гурван гишүүнийг зайлууллаа гэхэд л тийм үймээн хэзээний эхэлж байгаа нь тэр бөгөөд цаадуул чинь туршлагатай улс төрийн бодлоготнууд учраас яах ийхийн зуургүй уг үймээнийг ашиглана. Тэгсэн цагт чи бид хоёр лав тэднээс өршөөл үзнэ гэвэл санааны гарз. Хэрэв тэд нар засгийн толгойд гарах юм бол бид бүхнийг гурван үеийг нь барагдтал сөнөөнө. Гэтэл чи тэдэнд итгэж, тэдэнтэй эвлэрч байх юм. Тэд нар чамд баярлалаа гэж хэлнэ гэж бодож байна уу? Мөн ч хэлнэ вий, хонгор минь! Чи чинь гудамжаар явган зугаацаж, театрт юм үзэхдээ голын суудалд суудаг гэж байгаа шүү дээ. Болгоомжгүй, тун болгоомжгүй байна. Чи үнэхээр өөрөө ойлгохгүй байна гэж үү? Улс төрийн Товчоо чиний хамгаалалтын талаар тусгай шийдвэр гаргах ёстой болж байна уу? гэв.

–Ямар ч шийдвэр битгий гаргаарай гэж гуйя хэмээн Киров яаран өгүүлж, - Надад найдвартай бас хангалттай хамгаалалт байгаа гэв.

–Энэ бол чи тэгж үзэж байгаа хэрэг. Улс төрийн Товчоо энэ талаар өөр бодолтой байж болно. Улс төрийн Товчооны гишүүдийг хамгаалах тодорхой журам бий, ганцхан чи л түүнийг зөрчиж байна гэж Сталин зөрлөө.

–Би Ленинградад найман жил болж байна. Энэ найман жилд янз бүрийн юм болоогүй. Ямар нэг юмны сэжиг битгий хэл ажиг ч байгаагүй гэж Киров өчив.

–Өчигдөр юм болсонгүй, өнөөдөр юм болсонгүй, гэхдээ маргааш юм болж мэднэ, үүрдийн юм гэж байхгүй, эцэс төгсгөлгүй юм гэж байхгүй гэж Сталин зөрөв. - Гитлер засгийн эрхэнд гарсан явдал байдлыг үндсээр нь өөрчилж байна. Манай орны эсрэг хүчин одоо Германы милитарист санаархлаар дэмжлэг авч байна. Энэ милитарист санаархал нь юуны өмнө өрнөд рүү чиглэж байгаа нь эргэлзээгүй. Гэтэл Өрнөдийнхөн түүнийг бидний нуруунд үүрүүлчих гээд байна. Хэрэг явдал ингэж эргэж байгаа нь манайд хямралын байдал үүсгэж болно. Хэн тийм байдлыг юуны өмнө ашиглах вэ? Эсрэг хүчин... Манай оронд бид ямар эсрэг хүчинтэй билээ? Хаант засгийн талыг баримтлагчид уу? Кадетууд уу? Эсерүүд үү? Меншевикүүд үү? Тэд нар байхгүй болсон, тэднийг үүрд арчиж цэвэрлэсэн, буцаад сэргэх чадвар тэдэнд байхгүй, ард түмэн өөрийгөө үүрд зөвлөлтийн системтэй холбосон. Тэгэхлээр цорын ганц аюул бол зөвлөлтийн систем доторх намын доторх эсрэг хүчин юм. Тэд нар хэн бэ? Троцкистууд, Зиновьевчууд, Бухаринчууд. Тэд нар өөрснөө үүнийг ойлгож байгаа юу? Ойлгож байгаа нь эргэлзээгүй. Тэд одоохондоо аргалцгааж байна. Тэдний гол зорилго бол өөрснийгөө хямгадаж, боловсон хүчнээ хадгалж үлдэх явдал. Тэд цөөхөн үү? Хэдхэн мянга уу? Тэгвэл арван долоон онд большевикууд бид нар хэдүүлээ байлаа? Бас л хэдхэн мянган хүн байсан. Гэвч бид нар байдлыг зөв ашиглаад ялчихсан. Тэгэхлээр ардаа хэдэн мянга биш хэдэн түмэн нуугдмал санаа нэгтгэнтэй Зиновьев, Каменев, Бухарин мэтийн этгээдүүд боломжийн байдлыг ашиглаж чадахгүй гэж үзэх ямар үндэс бидэнд байна? Хуучин меньшевик байсан бүх хүн Зиновьевыг дэмжихгүй юм гэж үү? Хөрөнгөө хураалгасан тариачид, эсерүүд, кадетууд Бухариныг дэмжихгүй юм гэж үү? Тэд нар Зиновьев, Бухарин хоёрыг түр зуурын замын хань гэж үзэж байгаа, гэхдээ тэднийг ард түмэн ч мэддэг, нам ч мэддэг учраас хямарсан тодорхой нөхцөлд цорын ганц таарах хүмүүс гэж үзэж байгаа. Тэд нарын нөгөө гэмээ наманчилж, алдаагаа хүлээж байсан энэ тэрийг бол хэн ч нэхэж санахгүй. Зиновьев, Каменев хоёр арван долоон онд ямаршуухан алдаа гаргасан билээ дээ, гэвч дажгүй л байна, бүх алдааг нь өршөөж, цөмийг нь мартацгаасан. Троцкий Лениний эсрэг арван таван жил тэмцсэн, гэтэл большевикуудын талд орохтойгоо нь зэрэг түүний хамаг нүглийг өршөөж бүх юмыг нь мартацгаасан. Ард түмэн улс төрийн зүтгэлтний өнгөрсөн явдлыг биш, харин яг энэ мөчид хэн гэгч вэ гэдгийг л сонирхдог юм. Зиновьев, Каменев, Бухарин энэ тэр үүнийг маш сайн ойлгож байгаа. Алсын бодлогын наад захын зүйл шүү дээ. Тэдний хувьд бол амиа авч үлдээд л цагийн сайныг хүлээх явдал. Энэ талаар тэд Троцкийгээс илүү зальжин. Троцкий бол улс төрийн барагтайхан бодлоготон, тэр өөрөө ч гэсэн, тэдний талынхан ч гэсэн ердөө л хар муйхраар дайрцгаасан, тийм учраас бид тэднийг нэг бүрчлэн мэднэ, бүгдээрээ бидний хараанд байгаа. Зиновьев, Бухарин хоёр бол арай овтой улс, цаг алдалгүй бууж өгцгөөж, боловсон хүчнээ огт илчлээгүй, тэд нар нь нуугдзаначихаад хэзээ л бол хэзээ босоход бэлэн байгаа. Тэд нар олуулаа шүү, маш олуулаа. Намд болоод намаас гадуур гомдсон бүх хүн шүү

дээ. Аюултай бөгөөд томоохон хүч нөөц. Гэтэл “бид” энэ хүч нөөцийг ариглан хамгаалж, өмгөөлөн ивээж байна.

–Та Ленинградыг хэлж байна уу? гэж Киров асуув.

–Тийм гэж Сталин эрсхэн хэлээд, –Эсрэг хүчний бут ниргэгдээгүй түшиг тулгуур болж байгаа Ленинградыг хэлж байна, бас энэ бат цайзыг бут ниргэхийг хүсэхгүй байгаа хүнийх нь хувьд нөхөр Кировыг хэлж байна гэв.

–Энэ ч тийм биш шүү, намын түүх биднийг бас өөр зүйлд сургаж байна хэмээн Киров тайван өгүүлж, –Стратеги, тактикийн асуудлаар намын дотор эсрэг тэсрэг үзэл бодол үргэлж байсан, яриа маргаан ч гардаг байсан. Гэхдээ нам шийдвэрээ гаргамагц маргаан эцэс болж, цаашдаа ямар ч эсрэг хүчин байхгүй болдог төдийгүй хуучин эсрэг талын хэнийг ч болов намаас тасалж хаядаггүй байсан. Харин ч болбоос Ленин аль нэг асуудлаар төөрөлдөж байгаа хүмүүст нөхөр ёсоор халамжтай хандаж байхыг бидэнд сургадаг байсан.

Ленинградын намын байгууллагад ямар ч троцкистууд, зиновьевчууд, бухаринчууд байхгүй гэдгийг хариуцлагатай батлан хэлж байна. Бид намын эсрэг, зөвлөлтийн эсрэг үзэл бодлын салангид илрэлтэй тулгарч байгаа нь үнэн, гэхдээ тийм үзэл бодол үндсэндээ хөрөнгөтний ангиудын дотроос гарч байгаа болохоос биш намын доторх хуучин эсрэг хүчнийхэнд ямар ч хамаа байхгүй. Түүнээс гадна хорин таван онд Зиновьевын төлөө санал өгч байсан Ленинградын ажилчин коммунистууд Зиновьевтой аль хэзээний түнжин хагарч, түүнийг хэдийн мартсан. Тэгэхлээр намын сахилгын хүрээнд удирдлагынхаа төлөө санал өгсний учир одоо найман жил өнгөрсний хойно тэднийг би залхааж чадах ч үгүй, тэгэх ч үгүй. Хэрэв та миний улс төрийн бодлогыг буруу гэж үзэж байгаа бол намайг Ленинградаас татан авч болно, харин би Ленинградод байгаа цагтаа тэр бодлогоо өөрчлөхгүй гэж ярив.

Сталин түрүүнээс хойш илт цухалдаад байсан нь гэнэт намдаж, тэрээр тайван төдийгүй бүр хэнэггүй янзтай,

–Нам маань хот болгонд өөр өөр бодлоготой байж таарахгүй, нам бол бүхий л улс орны хэмжээнд нэгдмэл бодлоготой, тийм учраас аль ч мужийн намын хорооны дарга энэ л бодлогод захирагдах ёстой. Хуучин зиновьевчуудад хэрхэн хандах чиг шугамын тухай бид Улс Төрийн Товчоогоор хэлэлцэнэ. Харин бид тэр асуудлыг хэлэлцтэл зиновьевчууд идэвхжиж байна гэж миний анхааруулж байгааг чи бодолцож, зориуд болгоомжтой байхыг чамаас хүсэж байна. Надад чинийхийг бодвол арай өргөн хүрээтэй мэдээлэл бий. Сергей Миронович, чи дэндүү итгэмхий юм. Тэр хэтэрхий итгэмтгий зан чинь чамайг хөөдөх вий, мэдээтэй л байгаарай гэж хэлэв.

–Юу гэсэн үг вэ?

–Чи бол Зиновьев, Каменев хоёрыг зөвхөн их хурлуудын индэрт байхыг нь харсан, би бол тэдэнтэй цуг олон оймс элээсэн, Каменев бид хоёр бол цөллөгт хамт байсан улс. Тэр хоёр худалч хуурамч, мэхлэгч дүрэмдэгчид. Тэдний ард нуугдаж буй хүмүүс ч бас худалч, дүрэмдэгч өөдгүй амьтад. Тэдэнд бүү итгэ, тэд нар чинь юу ч хийхээс буцахгүй. Цаадуул чинь чамайг үзэн ядаж байгаа. Чи тэднийг хичнээн их өөгшүүлнэ, тэд чамайг төдийчинээ илүү үзэн ядна гэж мэд. Нэгэнт иймдээ хүрсэн хойно хэлэхэд чамайг Москва руу шилжүүлэх

санаатай байгаагийн нэг шалтгаан энэ. Хэрвээ чиний оронд өөр хүн очоод Лениградын ажлыг адилхан сайн амжуулаад байх юм бол цаадуул чинь юмны учир зөвхөн нөхөр Кировт байгаа бус намд байгаа юм байна, Лениградын коммунистууд зүгээр нөхөр Кировыг дагаж байгаа бус намаа дагаж байгаа юм байна гэдгийг ойлгож авна. Тэгээд чамайг залгамжилсан хүн рүү хэл амаа билүүдэхээ больцгооно. Ер нь чи чинь Төв Хорооны нарийн бичгийн дарга шүү дээ, чи аль эртний Москвад шилжиж ирвэл зохих байж, Төв Хорооны нарийн бичгийн дарга Москвад амьдрах ёстой. Ленинградад тасалбар халах ажлыг хийчих, Лениградынхан чамайг энэ ажлаар чинь санаандаа шингээж аваг, бас энэ ажил чиний салах ёс үйлдсэн үйлдэл ч гэх юм уу тийм зүйл болог, тэгээд л Москвад шилжээд ир.

Киров дүрсхийн шатсан хилэнгээ тогтоож доошоо харлаа. Түүнийг нэр төрд шунаж байгаа мэт битүүгээр дайрсан нь тун бүдүүлэг хэрэг байв. Бүх юм тодорхой боллоо. Сталин түүнийг Ленинградаас татан авч, Москвад дэргэдээ байлгах санаатай байх нь, тэгээд бүрмөсөн гартаа авахыг хүсжээ.

–Нөхөр Сталин, хотын шинэчлэн байгуулалт дуустал намайг Ленинградаас татаж авахгүй байхыг танаас гуйя. Би тэр ажлыг эхлүүлсэн, тэгээд өөрөө дуусгамаар байна гэж Киров хэлэв.

Тэрээр энэ тухай эрс шийдсэн хүний янзаар өгүүлжээ.

Сталин нэгд нэгэнгүй ойлгож,

–Шинэчлэн байгуулалт хэзээ дуусах билээ гэж тайван асуув.

–Энэ таван жилийн сүүл рүү болов уу гэж найдаж байна.

–За тэгвэл чамайг даруйхан Москвад татаж авахын тулд таван жилийнхээ төлөвлөгөөг дөрвөн жилд багтаахыг хичээе хэмээн Сталин тоглоом хийж өгүүлэв.

Варя яг есөн цагт ажилдаа ирж гэрэлтүүлэн буулгавал зохих зурагтай цаасаа самбар дээр дэлгэж дээрээс нь цэнхэр туяатай ёрог хальс давхарлан товхтой хатгуураар шигтгэж тогтоогоод Лёвочкагийн зааж сургасан ёсоор тусгай тосоор зэрвэсхэн арчихад гэрэлтүүлдэг хальс нь шил шиг тунгалаг болж, цаадах зураг нь дурайтал тодроод ирэх бөгөөд бэх нь сарниж баахгүй амар болдог ажээ. Лёвочка зургийг гараас гаргана. Тэрээр техникч болж яггүй дээгүүр зиндаанд хүрснээ харандааны ажилтай хүн хэмээн тодорхойлдог билээ. Даанч техникийн боловсролгүй болохоос биш ёстой сайн залуу, тийм боловсролгүй учраас зохион бүтээгч техник гэдэг нэрээрээ үнэнхүү бахархана. Игорь Владимирович зургийн эх нооргийг томъёолж, Лёва түүнийх нь дагуу нарийн зураг гаргаж, Варя гэрэлтүүлэн буулгана. Гэрэлтүүлсэн хальсыг гэрлийн хуулганд оруулж түүнээс хөвхөр дардас буюу ажлын зургуудыг хордуулан хэвлэж тэдгээрийг зэргэлдээ баригдаж байгаа зочид буудлын барилга руу шилжүүлнэ. Лёвочка эндхийнхний ярьдгаар “нандин зураасыг” эзэмшсэн буюу чанартай тов тод зурдаг учраас түүний зургаас харж ажиллахад хялбархан байдаг ажээ. Лёвочка Варяд зургаа шилжүүлэхдээ цонх, хаалга, буудлын үүдний танхимын хэсэг, давхрын танхимын хэсэг, рестораны хүлээн авалтын танхимын хэсэг гэхчлэн ерөнхийд нь тайлбарлахаас биш нарийн ширийн юмыг тэр болгон ярихгүй. Нарийн ширийн юмыг нь Игорь Владимирович ярьж өгнө. Тэрээр өрөөнөөсөө гарч ирж Варягийн дэргэд очиж зогсоод зураг руу тонгойн энэ зураас ийм учиртай, тэр зураас тийм учиртай хэмээн тайлбарлаад,

–Ойлгогдохгүй юмаа асууж байгаарай, санаа зовохын хэрэггүй... гэж нөхөрсгөөр өгүүлнэ.

Лёвочка, Рина хоёрын ярьснаар бол тэднийг буулгагч хийдэг байхад сохроор битгий хуулаасай, хийж байгаа ажлаа ойлгоосой гэсэндээ Игорь Владимирович тэдэнд мөн ингэж тайлбарлаж өгдөг байжээ. Албархах хэнээтэй дарга нар байдаг, тийм дарга бол хүрч ирж харчихаад “Өө хонгор минь, чи чинь баллаад хаячихаа шив... Наадхыгаа авч хая, шинээр хуул” гэнэ. Игорь Владимирович бол хэзээ ч тийм үг хэлэхгүй, тэрээр дарга шиг төдийгүй сурган хүмүүжүүлэгч шиг харьцана. Гаднаас нь харахад Игорь Владимирович Варяг ямар нэг байдлаар илүүд үзсэн шинжгүй бусдын нэгэн адил харьцана. Гэхдээ өөрт нь бусдаас өөрөөр хандаж буйг Варя анзаараад байгаа учир түүнийг өөгшүүлэхгүйн тулд асуух юмаа Лёвочка, Рина хоёрын аль нэгнээс асуудаг байв.

Тэрээр ажилдаа түргэн дадаж уймрах, сандрах, тээнэгэлзэхийн алийг ч амссангүй. Чиг, шугам, гурвалжин, нуман шугам, гортиг, бэхний үзэг мэтийн багаж хэрэгслийг сургуульд байхын мэдэх бөгөөд гэрэлтүүлэх хальсаа сурамгай гэгч нь толийлгож бэхэлнэ. Бэхээ зураг дээрээ баалгахгүйн тулд үзгээ зайдуухан цэнэглэнэ, хэрвээ дусчихвал сахлын хутгаар ямар ч ор мөр үлдээлгүй чадмаг хусдаг тул Лёвочка, Рина хоёр хүртэл гайхширна. Бас муруй зураасыг буулгахдаа нуман шугам хэрэглэхгүй нарийхан үзгээр болгочихдогийг нь гайхна.

Арван хоёр цагт тэд нар Тверийн гудамж, Белинскийн гудамж хоёрын уулзварт байдаг хаалттай гуанзанд очиж үдийн хоол идэцгээхээр шуугилдан хөдөлцгөөнө. Үдийн хоол нь манжингийн салаат, ногооны буюу ердийн шөл, хэрчим махтай буюу котлеттай агшаасан будаа, жимүүснээс бүрдэх бөгөөд дөнгөж дөчин копейкийн үнэтэйн гадна хүнсний тасалбараас тасдаж өгөх шаардлагагүй ажээ. Нэмэрт нь буфетнээс хиам, бяслаг, эсвэл май

загастай нэг хоёр талхны зууш бас тасалбаргүйгээр худалдан аваад явж болно. Товчоонд дөчөөд хүн ажилладгийн тэн хагас нь залуухан сайхан охид байх бөгөөд Варя тэдний зарим нэгтэй “Эрмитаж” цэцэрлэг, “Националь”, “Метрополь” энэ тэрд тааралдаж явсан ажээ. Түрүүлж ирсэн нь нөгөөдүүлдээ кассанд оочер авч цөмөөрөө эвсэг найртай, тоглоом тохуу хийлцэн байна. Энэ охидын дарга нар болох уран барилгачид, инженер, техникчид мөн адилхан энгийн нөхөрсөг харьцацгаана.

Хоолоо идэж дуусахын хэрээр хоёр гурваараа нийлэн буцацгаана. Зоя зочид буудлын суурь тавих газар шорооны ажил хийгдэж байгаа хашаагаар хүрээлсэн барилгын талбай руу нүдээ дүрлийлгэн зааж,

–Ноднин Охотный ряд гудамжинд муусайн мухлаг лангуунуудыг хуу нурааж зайлуулсан, тэнд мах, загасны худалдаа хийдэг байсан болохоор үхэр хулгана сүрэглээд үүрлэчихсэн байсан юм. Гэтэл, чи бодоод үзээч, тэр олон муур шиг том тарган цаггалан үхэр хулгана чинь “Гранд-отель” руу сүрэглэн дайрч ороод өрөө тасалгаа, дээд доод давхруудаар тарчих нь тэр. Бүү үзэгд! Бид нар ухаан гартлаа айж, ширээн дээрээ авирч гарцгаасан гээч. Тэр үхэр хулганын сүргийг тусгай бүлэг ирж устгасан, тэр ч байтугай нэг хэсэгтээ зочид буудлыг хаахаас өөр үггүй болсон юм гэж ярина.

Зоя ер өөрчлөгдөхгүй юм. Тэрээр хэзээний ийм олон үгтэй, байнга хөөрч хөвсөлзөж, хүн ээрээд салдаггүй нэгэн билээ. Товчооныхноос түүнтэй үерхдэг, түүнийг тоодог хүн гэж огт байхгүй. Варя ч гэсэн түүнийг сонирхдоггүй боловч үерхдэг бүсгүйгээ хөөж тууж эс чадах тул хоосон бурахыг нь тэвчин тэвчин сонсоно. Цаадах нь ч ховын тулам л гэсэн үг.

–Зочид буудлын төсөл бол Игорь Владимирович бас өөр нэг уран барилгач хоёрынх, тэр хоёр уралдаант шалгалтаар тэргүүн шагнал авсан юм. Гэтэл академич Щусевыг тэр хоёрт хамтран зохиогчоор томилчихсон төдийгүй түүнийг ерөнхий удирдагчаар томилсон. Тэр хоёрт гомдолтой байлгүй яахав. Щусев чинь энд ч суудаггүй, Брюсовын хөндлөн гудамд байдаг өөрийнхөө урлангийн газар суудаг юм, мэднэ биз дээ, нөгөө Качалов энэ тэр гээд баахан алдартай жүжигчдийн байр шүү дээ. Мэдэх үү? хэмээн Зоя дуржигнуулна.

–Би ч мэдэхгүй л дээ, харин чи яаж мэддэг юм бэ? Качаловынхоор зочилж орж гардаг юм уу? гэж Варя доогтой асууна.

–Тэднийд ч очдоггүй л дээ, гэхдээ тэр байшин хаа байдгийг мэднэ. Би Щусевг зураг зөөж аваачиж өгдөг байсан юм.

Варя Щусевыг харсан билээ. Тэрээр жар эргэм насны нүдэнд дулаахан өвгөн бөгөөд Товчоон дээр бараг өдөр болгон ирдэг байжээ. Нэг удаа тэдний өрөөгөөр орж ирсэн юм. Тэгэхэд Лёвочка ямар нэгэн дээгүүр даргад зориулан зочид буудлын бүтэн гадаад байдлыг зурж байсан. Яаралтай ажил учраас өдөр шөнөгүй ажиллаж байсан.

Щусев зургийг хараад сайшаан толгой дохиж,

–Маш сайн байна, харин цонхыг нь арай нарийсгаж харуулах хэрэгтэй гэчихээд гараад явчихжээ

Лёвочка балмагдан сандарч сандал дээрээ лагхийтэл суув.

–Чи яачихав? хэмээн Рина асуув.

–Би цонхнуудын хоорондох зайг туйпуун өрлөгөөр гаргасан юм. Цонхыг нарийсгах юм бол бүх туйпууг дахин зурах хэрэг гарна. Бас нэг шөнийн ажил.

–Би чамд тусалъя, тэгэх үү? гэж Варя санал хэлэв.

Лёвочкад туслах хэрэгцээ гараагүй. Игорь Владимирович,

–Бүү гар хүр. Маргааш түүнд засчихсан гээд хэлчихээрэй гэж хэлжээ.

Маргааш нь Щусев дахиад орж ирэв.

–Хийчихсэн үү?

–Тэгсээн.

–Харахгүй юу, шал өөр байна шүү дээ.

Энэ явдлын тухай хожим байсхийгээд л инээдэм болцгоодогсон. Ер нь Щусевыг тохуу хийх нь элбэг. Тэрээр зочид буудлын Манеж руу харсан хажуу талыг хэдэн багана дээр ресторан байрлах хайрцаг байгаа мэтээр төсөөлжээ. Энэ хайрцгийг товчооныхон дооглон “авдар” хэмээдэг боловч өөриймсөг сэтгэлээр тэгдэг болой. Энд энэ барилга байгууламжийн төлөө сэтгэлээ зориулсан цөөхөн ч гэсэн гар нийлсэн эвсэг хамт олон ажиллаж байгаа учир элдэв засварт цөмөөрөө гутарч амжилтдаа бүгд баярлацгаадаг ажээ.

Щусевыг Игорь Владимирович өөрөө ер шүүмжилдэггүй, хажууд нь өөр хүн шүүмжлэхийг ч эс зөвшөөрдөг билээ. Тэрээр нөгөө цонхны явдал шиг бүх юмыг санаснаараа хийдэг боловч түүний заалтыг хэзээ ч үгүйсгэж маргадаггүй аж. Цаад хүн нь эрхбиш Щусев учраас Игорь Владимировичийн тийм зан Варяд аятайхан санагддаг юм. Хэрэв Игорь Владимирович түүнийг егөөд байх юм бол өөрийгөө доромжилсон хэрэг болохсон. Гэтэл Игорь Владимирович чинь нэртэй хүн шүү дээ! Тэрээр дорд ажилтан нарынхаа ноорог зургийг үзэхдээ эндхийнхний ”сүмс” гэж нэрлэдэг хар нүүрсээр энд тэнд нь хэдэн зураас татдаг бөгөөд мань хүний заалт чухам тэр учраас цаадуул нь үг дуугүй ёсчлон биелүүлцгээнэ. Даруу, түвшин, дэгжин янзын эр. Олон охид түүнд ухаан жолоогүй дурласан боловч энэ талаар түүний нэр хүнд эндээ ямар ч өө сэвгүй болой.

Нэг удаа Варя, Игорь Владимирович, Рина, Лёвочка дөрөв гуанзнаас хамт буцаж тааржээ. Рина, Лёвочка хоёр жаахан түрүүнд нь, Игорь Владимирович, Варя хоёр арханд нь зэрэгцээд явцгааж байв. Игорь Владимирович “Националь” руу нүдээрээ дохиод,

–Энэ буудал танд юу ч санагдуулахгүй байна уу? гэж асуув.

Варя гуанз руу очих, тэндээс буцах замдаа “Националийн” дэргэдүүр өдөрт хоёр удаа өнгөрдөг бөгөөд энэ буудал түүнд ер нь юу ч санагдуулдаггүй билээ. Энд аль эрт хавраар

Викагай нэг удаа орсон, тэр үед төрсөн сэтгэгдэл нь хожим Костятай цуг хэссэн олон ресторанаас төрсөн сэтгэгдэлд шахагдан арилсан болой.

–Та бид хоёр энд танилцсаныг санаж байна, би тэгэхэд Вика Марасевичтэй явж байсан гэж Варя тайван өчив.

–Тэгвэл Александрийн цэцэрлэгийг санаж байна уу? Сандлаар хаасан үүд, манаач нь шүгэлдсэн... Зугтсан... та оймсоо урсан энэ тэрээ...

Түүнд энэ дурсамж дотно байдаг нь илт. Үүнийг бодохоос Варягийн зүрх ч гэсэн шимшрэн гөхөлзөнө. Тэр үед өөр цаг, өөр амьдрал, өөр горьдлого найдвар байжээ. Харин Игорь Владимирович саяынхаа үгийг хариу хүссэн янзтай хэлжээ... Тэгэхийн хэрэг юу билээ? Тэрээр нөхөртэй хүүхэн! Хэр зэрэг удаан ийм байх бол? Одоо ч бодвол удаан ийм байхгүй вий. Тэглээ ч гэсэн...

–Нээрэн тиймэрхүү явдал байсан шүү гэж Варя хайхрамжгүй хариулав.

Игорь Владимирович Варяд аятайхан санагдаж байгаа нь эргэлзээгүй. Гэхдээ зөвхөн хүнийхээ чанараар л тэр. Нөгөө “Национальд” уулзах үед л Варя түүнийг Вика болон түүний нөхдөөс өөр хүн гэдгийг дор нь ойлгосон юм. Тэгээд одоо ажил дээрээ олон гарамгай хүмүүсийн дунд байгааг нь харж байна. Щусев ирж байсан. Казаний галт тэрэгний буудлын танхимуудын чимэг зургийг бүтээсэн нэртэй зураач Лансере ирж байсан, одоо энэ хүн шинэ буудлын гол рестораны адрын чимэглэлийг зурна, хөргөгч зэрэг гал тогооны хамгийн сүүлийн үеийн техникийн зөвлөх нэг америк хүн ирж байсан, төслийн нарийн ширийн зүйлийг зохицуулах уран барилгачид, инженерүүд ирж байсан. Дараа нь Лёвочкагаас эдгээр хүний нэрийг сонсоход дандаа л алдар цуутнууд байсан.

Варя орой ажлаасаа явмааргүй, гэртээ эргэж очмооргүй санагдана. Тэрээр Костяд хайргүй, зөвхөн өрөвддөг боловч өөрөө түүний амьдарч яваа шиг аж төрж чадахгүйгээ мэджээ. Костя тэгэхэд түүнд “Магадгүй, би чиний дэргэд л хүн болох ч юм билүү” гэж хэлж байсан. Хов хоосон үг, тэрээр хүн болоогүй, цаашдаа ч болохгүй.

Нөгөө нөмрөгний явдлаас хойш мань эр юу ч болоогүй юм шиг, мөрийчний амьдрал ийм л байдаг юм, өнөөдөр хожно, маргааш хожигдоно, өнөөдөр мөнгөтэй байна, маргааш өл залгуулах юмгүй явна, одоо яая гэх вэ, түр зуур аз харьсныг давж тэвчээнэх хэрэгтэй гэсэн мэт хэнэггүй царайлах болжээ. Варя дуугарахаа больж биеэ хураан хүйтэрч хөндийрснийг Костя харж байгаа тул өөрийнх нь тоочиж байгаа шалтгийг хүлээж авахгүй байна гэдгийг ойлгож байв. Тэглээ ч гэсэн Варяг өөрийнхөө амьдралын эрхшээлд оруулахыг махран улайна. Нэг удаа алтан бугуйвч авчирч гарт нь углаж өгөөд,

–Зүүж яв! гэж хэнэггүй өгүүлжээ.

Цаадах нь бугуйвчийг мултгалж ширээн дээр тавиад,

–Би үүнийг чинь зүүхгүй ээ гэж өчив.

–Яагаад?

–Би хэзээ ч алтан эдлэл хэрэглэж яваагүй, хэрэглэх бодол ч байхгүй.

Костя түүн рүү улангасаж уурссан харцаар хялалзсан боловч биеэ барив.

–Зүүхгүй бол тэр л биз, чиний бугуйвч шүү. Тэрээр бугуйвчийг хайрцагт хийж цаасанд нямбайлан боогоод ширээний татуурга руу шургуулж цоожилсноо,

–Эмэгтэй хүнд чинь үнэтэй цайтай юмаа хийдэг гоё хайрцаг байх ёстой. Гэвч одоохондоо чамд гоё хайрцаг алга, тийм учраас энд байж байг гэж тоглоом болгож өгүүлэв.

Варя энэ бугуйвч гэнэтхэн гарч ирсэн шигээ мөн гэнэтхэн алга болчихно гэж мэдэж байсан учир хариу юу ч хэлсэнгүй.

Цаадах нь мөн тэр өдрөө ширээний нүдэнд баахан мөнгө бас орхив. Варя тэр мөнгөнд нь огт гар хүрсэнгүй, тэр ч байтугай хэд байгааг нь ч мэдэхгүй байв.

Костя нэг удаа,

–Чи яагаад мөнгөнөөсөө авахгүй байна? гэж асуув.

–Яах гэж авах билээ? Чи гэртээ хоол идэхгүй байна, би ажил дээрээ үдийн хоол идчихэж байна.

–Үдийн хоолонд ч гэсэн өртөг төлөх хэрэгтэй шүү дээ.

–Миний цалин тэрэндээ хүрдэг юм.

Төдөлгүй мөнгө ч арилж, бугуйвч ч алга болов. Варяд мөнгөний хэрэг байхгүй, бугуйвчны хэрэг ч бас байхгүй, гэхдээ элдэв будлианаас сэрэмжилж, ийнхүү юм алга болсныг түүнд заавал хэлэх ёстой.

–Ляленька, энэ удаа намайг бас л өршөө, би эргэж хожоод бүх юмыг буцаагаад байранд нь хийчихнэ, битгий гутар гэж Костя хариулсан ажээ.

–Надад гутарсан юм алга, юу ч буцааж авчрахын хэрэггүй. Надад мөнгө, бугуйвч хоёрын аль нь ч хэрэг байхгүй. Тэр юмнууд чинь алга болчихсон байхаар нь би чамд мэдэгдэх нь зүйтэй гэж санасан юм. Уул нь ч чамайг өөрөө авсан гэдгийг ойлгож байсан л даа.

Костягийн дуу чангарч,

–Намайг авсан гэж ойлгосон юм бол надад хэлэхийн хэрэг юу байна? гэв.

–Чамд ийм мэдээ сонсоход эвгүй байна уу? Үүнээс хойш элдэв үнэтэй эд, мөнгө энэ тэр нааш нь битгий авчирч бай, өөр газар хадгалж бай.

–Чи юу хэлэх гээд юу хэлж байна?

–Энэ бол барьцааны газар буюу хадгаламжийн касс биш. Тийм газар хадгалуулсан нь илүү найдвартай, харин энд болохоор Софья Александровна бид хоёр хариуцах ёстой болчихоод байх юм.

–Чи миний амьдралын нөхцөлийг ойлгохыг хүсэхгүй байна.

–Тийм ээ, би хүсэхгүй байна. Ийм амьдралыг би ойлгож ч чадахгүй, хүлээж авч ч чадахгүй.

–Чи намайг хөндлөнгийн хүн шиг ярьж байна. Варя түүн рүү эргэж нүд рүү нь эгцхэн хараад,

–Үнэхээр чи бид нар хүний хүмүүс, тийм учраас салах нь л хамгийн зөв зам гэв.

–Өө тийм бий! хэмээн Костя ярвайн үгээ сунжруулан зөөж - Би азтай явахдаа сайн хүн, аз нь харьчихлаар хэрэггүй хүн болж байх шив гэв.

–Тэр тийм биш гэдгийг чи сайн мэдэж байгаа шүү дээ. Би Крым явна гэж чамайг шахаж шаардаагүй, хар үнэг, алтан бугуйвч энэ тэр бас гуйгаагүй. Зүгээр л чи бид хоёрт нэг гэр бүлийн амьдрал алга, цаашдаа ч бий болохгүй гэдгийг би сайтар ухаарч авлаа. Костя муухай харсан чигээрээ,

–Уран барилгачтай явалдаж эхлээ юу? гэж шүд зуув.

–Тэнэг толгойт! гэж Варя тоомсоргүй өчсөн боловч дотроо хэн нэг нь алтан хошуу өргөчихжээ, хэн байх вэ? Лёвочка юу, эсвэл Рина юу? гэж бодов.

–Мэдээж тэнэг л дээ хэмээн Костя шатсан уураа барьж ядан үгээ сунжруулж, –Ресторан санаанд нь таарахгүй байна гэнэ, үгүй ер дөө, чи бид хоёр чинь хаана танилцсан улс болж байна, ресторанд биш гэж үү? гэв.

–Чи намайг ресторанаас олж авсан, рестораны банзал хүүхэн гэж хэлэх санаатай байна уу?

Костя биеэ барив.

–Би ганцхан зүйл л хэлэх гэсэн юм. Чи бид хоёр ресторанд танилцсан, тэгэхлээр тэр баримтыг гуйвуулахын хэрэггүй гэдгийг л хэлэх гэсэн юм.

–Надад гуйвуулах юм алга, чамтай ярих юм ч алга. Чи бид хоёр салах ёстой. Нэн даруй! Энэ өрөөг өнөөдөртөө багтааж сулла!

Цаадах нь гайхсан төдийгүй дооглосон маягтай мүдээ бүлтийлгэж,

–Өнөөдөр ий? Сонин хэрэг байна... Чи бид хоёр чинь хаашаа нүүх болж байна? гэв.

–Би гэртээ харина. Чамд бол бүртгүүлсэн байр чинь байгаа.

Костя энэ удаа хямсайн жуумалзаж,

–Тэр бүртгэл бол ёс төдий зүйл, би тэнд аж төрж чадахгүй гэж чамд хэлсэн шүү дээ. Ер нь ч би эндээс хаашаа ч гарахгүй. Надад энд болж байна гэв.

Тэрээр Варягийн самгардаж буйг үзээд яаж дөнгөснөө ойлгож ялан дийлэгчийн янзаар марсайтал инээмсэглэж байв. Варя үнэхээр балмагджээ. Тэрээр Костяг Софья Александровнагийн орхиж чадахгүй юм. Софья Александровна түүнийг дийлэхгүй, сэргийлэхэд хэлж хөөлгөхөөсөө айна, хэрүүл маргаанаас нь ч айна, өрөөгөө хураалгачих вий ч гэж айна. Ээ тэнгэр минь, “нээрээ яасан хөнгөн хийсвэр хөдлөө вэ, Софья Александровнаг ийм муухай явдалд хутгачих гэж байх уу даа.

–Софья Александровна энэ өрөөг надад хөлслүүлж байгаа юм.

Костя түүний үгийг тасдаж,

–Бидэнд! “Надад” биш бидэнд. Тэгж ярих юм бол би хөлсийг нь төлж байгаа гэв.

–Би тэр мөнгийг чинь буцааж өгнө.

–За тэгвэл, чи аан гээд анхааралтай сонсож бай хэмээн Костя нухацтай өгүүлж, -Чи бид хоёр анх удаа “Савойд” танилцах үед л чи энэ өрөөний тухай надад хэлж, эзэнтэй нь ярилцаж өгөхөөр амлаж байсан, тэгэхлээр надад зориулж хөлсөлсөн хэрэг шүү дээ. Гэтэл би одоо эндээс тонилох ёстой юм гэнэ. Хаашаа тэр вэ? Гудамжинд гарах уу? Үгүй шүү, би гадаа амьдарч чадахгүй, би энд л амьдарна. Харин чи бол дуртай газраа амьдарч болно гэв.

Варя толгойгоо ганзагалан дуугүй сууна... Ямар ч хүнийг өрөвдөхөө мэддэггүй, ямар ч арга хэрэглэхээс буцдаггүй ийм цэвдэг хүйтэн сэтгэлтэн байх гэж. Гэтэл өөрөө ийм хүнийг эр нөхрөө гэж нэрлэж явжээ. Түүнийг Софья Александровнад үлдээх эрх өөрт нь байхгүй учраас энэ бүхнийг тэвчин хүлцэхээс өөр зам алга, хамгийн аймаар юм энэ л байна.

Варя ийнхүү арчаагаа алдаж, доромжлуулж байхаас өөр аргагүй байгаад Костяд ёстой бах нь ханаж,

–Надтай амьдрах хүсэл байхгүй бол тэр л биз, энэ бол чиний мэдэх хэрэг, чи бид хоёрт гэр бүлийн баталгаа байхгүй юм чинь харсан харсан зүгтээ салж одоцгооё. Би чамайг албадахгүй, ер нь би хэнийг ч албаддаггүй хүн, Софья Александровнаг ч мөн нэгэн адил. Би энэ өрөөг чөлөөлж эндээс явна. Гэхдээ хотын төвд утастай сайхан тохилог байр олохоос нааш явахгүй. Үүний тулд хоёр гурван сарын хугацаа хэрэгтэй. Энд би ганцаараа үлдэх үү, хоёулаа байх уу гэдгийн тухайд бол надад огт ялгаа алга, чи бид хоёр бие биедээ саад болохгүй. Хоёр гурван сар л хэрэгтэй. Миний болзол ийм байна. Гэхдээ түүнээс наана өрөө олдвол би тэр тухайд нь л гараад явчихна хэмээн жуумалзсанаа, -Хэрвээ чи тэгтлээ их хүсээд байгаа юм бол надад байр олоход тусал гэж дээрэлхэв.

Цаг хожих санаатай байх нь, харьцааныхаа аяыг нь олно гэж найдаж байх нь, эцсийн бүлэгт эвлэрч өөрийнх нь амьдралыг хүлээн авна гэж найдаж байх нь. Тэгж найдсаны гарз байлгүй.

Гэвч энэ нөхөр нэг зуухаараа тас зуух хүн юм. Яг хавханд хийчихлээ. Өөр ямар ч арга алга. Тэрээр Софья Александровнад хэзээ ч гай болохгүй.

–Байрны тухайд би чамд тусалж чадахгүй, харин хоёр сар бол хүлээж болох юм гэж Варя хэлэв.

Цаадах нь үгийг нь тасдаж,

–Би хоёр гурван сар гэж хэлсэн шүү гэв.

–За яахав, хоёр гурван сар болог. Харин хоёр гурван сарын дараа бид энэ өрөөг чөлөөлнө гэдгийг чи надад амлалаа шүү.

Костя хуучин янзаар нүүр дүүрэн малилзтал инээж,

–Ингээд л хэл амаа оллоо шүү дээ. Хэрэлдэж, бие биеийнхээ тархи толгойг зовоож байхын хэрэг юу байна?! За ингээд эвлэрлээ! Ура! Үүнийгээ тэмдэглэж нэг газар очиж жаахан сууцгаавал яасан юм бэ? гэв.

–Чи бид хоёр үүнээс хойш хаа ч цуг наргихгүй. Би гагцхүү Софья Александровнаг бодож, түүнийг тайван байлгая гэсэндээ л энд үлдэж байна. Бусад бүх юмны тухай чи март. Би энэ жижигхэн буйдан дээр унтаж байна.

–Энэ жижигхэн дээр үү, багтах юм уу? хэмээн Костя инээд алдав.

–Багтана, чи бүү зов.

–Юу сайхан, дур сайхан.

Яагаад ингэж хууртчихав аа? Костягийн өнгөн дээрээ бэлжүү, хүнээс хамаарахгүй юм шиг байдлын цаана юу нуугдаж байсныг олж харсан ч үгүй, таамаглаж гадарласан ч үгүй. “Чиний дэргэд л хүн болох ч юм билүү” гэсэн хөсөр үгэнд яагаад толгойгоо мэдүүлчихэв ээ, тэр чинь ганцхан өөрийгөө л жинхэнэ хүн гэж үздэг шүү дээ. Өөрөө ангийнхан дотроо хамгийн гоё, хамгийн чадвартай, хамгийн сайн суралцдаг охин байсан, бусад охид нь түүнээс арван хуруу дутуу байсан атал тэдний нэг нь ч ийм явдалд орооцолдоогүй, тэр Арбатын сэхээтэн охидын хэн нь ч гэсэн мөрийтэй бильярдчинд толгойгоо эргүүлүүлэхгүй л дээ.

Варя өөрийнхөө учрыг олж, эцсийн бүлэгт өөрөө хэн бэ гэдгийг заавал ойлгож авах хэрэгтэй болж байна.

Тэрээр гарын үсгээр нь Зуев Инсаровын өөрт нь өгсөн тодорхойлолтыг дахин уншиж үзэв. Тэр тодорхойлолт анх хийж өгсөн дугтуйдаа байсан аж. Дугтуйн дээр хажуу тийш харсан ажилчин, тариачин, цэрэг гурвын зурагтай марк наалттай байна.

“Гойд авьяастай жирийн бус хүн. Ухаан хэрсүү. Шийдмэг зориг бий, гэхдээ зориглох нь үе үе илэрнэ. Биеэ даасан зантай, бусдын зөвлөлгөө, туслалцаагүйгээр бүх асуудлыг шийднэ. Ой ухааны хөгжил сайн, шинжлэх ухааны асуудлын учрыг бие дааж олж чадна. Шинжлэх ухааны

салбарт бүтээлчээр ажиллах авьяастай, гэхдээ зорьсондоо хүрэх талаар сул учраас тэр нь тодроогүй байж магадгүй. Өгөөмөр сэтгэлтэй, хүнд юугаа ч хайрлахгүй өгч чадна, харин хүнтэй нэг муудалцвал зангаа эрс хувиргана. Нэрээ их хичээдэг, гомдох нь амархан, нэг шийдсэн юмнаасаа хэн ч хорьсон буцдаггүй хүн. Түргэн зантай, бас хорон үг хэлж чадна. Зүрхтэй, тэр болгон болгоомжтой ханддаггүй хүн. Сэтгэлийн шаналгаатай үедээ зожиг. Ойр дотнынхоо хүмүүст зарим талаар хэтэрхий ширүүн. Бэлжүү зантай, бие сэтгэлийн жаргалаас үл буцна. Өөртөө итгэлтэй хүнд дуртай, халирхай хүнийг эс тэвчинэ. Мөнгөний тухайд маш шударга, энэ талаар өөрийгөө хохироох нь элбэг. Муу санах явдал бий, гэхдээ өс хонзон бодохгүй, дайснаа жигшин үзэж мохооно. Мэдрэлийн сэрэл хурц, хүнд хямралыг нууж ганцаараа шанална. Хоёр ааштай, зан тогтворгүй, баяр хөөрийн сэтгэл мөрөөсөл гунигаар солигдоно. Хайр сэтгэлийн харьцаанд эрээгүй улигт байдлыг эс тэвчинэ. Омогноосоо болоод яльгүй шалтгаар ч гэсэн бүх юмыг хаяж чадна. Гарын үсэг судлагч Зуев-Инсаров”.

Авьяас, чадварын тухайд бол Варя мэдэхгүй юм байна, бодвол тэр нөхөр хүн болгоныг ингэж магтдаг биз. Гэхдээ Зояд ийм зүйл бичээгүй байсан. Ямар ч атугай энэ тодорхойлолт түүний гэрлэсэн тухайд олон зүйлийг тайлж өгч байна... өөртөө итгэлтэй хүнд дуртай, бүх юмыг өөрөө шийддэг, санаснаар нь болгохгүй бол байж ядна, болгоомжгүй, бие сэтгэлийн жаргалаас буцдаггүй - энэ бүхнээс болж л баларсан байна. Сайхан тодорхойлолт, гэхдээ өөрийнх нь тухай дэндүү олон сайн юм байгаа учраас түүнийг хэнд ч үзүүлдэггүй билээ. Хүнд хямралыг нууж ганцаараа шаналдаг гэдэг л хамгийн үнэн зүйл. Энэ тохиолдсон явдлынхаа зовлонг ч бас л ганцаараа эдэлж байна.

Одоо Костя тэр хоёр тааралдахаа бараг больжээ. Цаадах нь ёс шиг шөнө дундаас хойш ирнэ. Варя нөгөө жижиг буйдан дээр унтдаг бөгөөд өглөө Костяг унтаж байхад ажилдаа яваад өгнө. Костя түүний бүсгүй хүний олон занг нигүүлсэн өршөөх мэт найрсаг харьцахын хамт оролдож зовоодоггүй байлаа. Ширээний шургуулганд дахиад мөнгө бий болж, хувцасны шүүгээнд өөрт нь таарах үстэй шаахай байхыг Варя нэг удаа харжээ. Костя тэвчээртэй хүлээж байв. Амралтын өдрүүдэд зовлонтой болж мэдэхээр байвч Варя амрахгүй ажилдаа явчихна. Тэдний товчоо аливаа бусад байгууллагын нэгэн адил тасралтгүй ажиллах дэглэмтэй, ажил элбэг, ажилтан нараа долоо хоногт нь гүйлгээ хуваариар амраадаг учир тэд амралтынхаа өдрийг авахгүй бол дарга нар нь уухайн тас баярладаг ажээ. Амраагүй өдрийг нь сүүлд ээлжийнх нь амралтан дээр нэмээд өгчихнө. Варя Костягийн аяыг харахгүйн тулд аль болохоор мөнгө олохыг хичээж гэр орноороо “хажуугийн” ажил авчирч хийдгийн гадна Зоятой кинонд явахаа ч бараг больжээ.

Завгай орой таарвал Варя Михаил Юрьевичийн ном, цомог, хавтсаар дүүрэн шүүгээ, тавиур, дөгнүүр шахаж тавьсан өрөөнд орно. Номын дөгнүүрийн доогуурх нэг зайд нарийхан ор, нөгөө нэг тийм зайд шахдаг цавуу, будаг, шилэн аягатай үзэг бийр, харандаа энэ тэр тавилсан бичгийн ширээ байх бөгөөд хайч, хутга зэрэг Михаил Юрьевичийн ажлын багаж хэрэгсэл тэнд нь байна. Ширээний дэргэд суудал нь үлхийсэн өндөр аравчтай хуучин олбогт сандал байна. Варя энэ сандал дээр бүүр гараад суучихна.

Будаг цавууны үнэр аятайхан ханхалж, хавчдаг шилтэй хуучин цагийн ганц бие эр Михаил Юрьевич бас цаанаа нэг тухлаг харагдана. Тэрээр нэг газар албатай, өглөө эртлэн одож, ажлаасаа яг зургаан цагт буцаж ирнэ, түүнээсээ хожимдлоо гэвэл шинээр худалдаж авсан

ном, сийлбэр буюу хуулбар уран зурагтай орж ирнэ. Түүний амьдрал чухам энэ. Номынхоо хавтсыг өөрөө сэлбэж, хуудсыг нь нэг бүрчлэн наана. Маш нарийн товъёг хөтөлж, түүнийхээ дагуу тоо томшгүй олон тавиур дээрээс хэрэгтэй юмаа дорхноо олно. Варя ном авч үзэхэд номоо яаж барьж байгаа, хуудсыг нь яаж эргүүлж байгаа, авсан газартаа буцааж тавьж байгаа эсэхийг Михаил Юрьевич хардаж болгоомжилсон байдлаар гар дагуулан харна.

Михаил Юрьевич өвөл зунгүй энгэр тохой нь гөлийсөн ганц костюмаа ноолж, бүх юмаар өөрийгөө хавчиж байж цөөхөн цалингаараа ном авна.

Тэрээр номын өгөршсөн хуудсыг нимгэн цаасанд наах зуур,

–Хүний бүтээсэн бүх зүйлийн дотроос хамгийн агуу нь ном, хорвоогийн бүх хүний дотроос хамгийн гайхалтай үзэгдэл нь зохиолч. Бид Нэгдүгээр Николай, Бенкендорф хоёрыг мэдэж байгаа чинь тэр хоёр гагцхүү Александр Сергеевич Пушкинтай нэгэн үед амьдарч таарсан учраас л тэр. Библи судар байгаагүй бол бид хүн төрөлхтний түүхээс юу мэдэж байхсан билээ? Бальзак, Стендаль, Мопассан байхгүй бол Францын тухай юу мэдэх вэ? Үүрдийн настай ганц юм бол үг хэмээн яриа дэлгэнэ.

–Тэгвэл суварга, сүм дуган, уран барилгын дурсгал, Сэргэн мандалтын үеийн агуу гайхамшигт уран зураачид юу юм бэ? гэж Варя зөрнө.

–Микеланжело, Рафаэль энэ тэрийн бүтээлээр нүд хужирлаж сэтгэлийн жаргал эдлэхийн тулд Ром, Флоренц, Дрезден рүү явах хэрэгтэй. Лувр юм уу манай Эрмитажид очих хэрэгтэй. Гэтэл Данте юм уу Гёте руу явах хэрэг байхгүй, тэд нар үргэлж надтай хамт байна гээд Михаил Юрьевич номын шүүгээ тавиураа эргүүлдэн харна.

–Энэ номын сан ч таны цайз л гэсэн үг юм аа, та тэгээд дотор нь бүгж байна хэмээн Варя инээмсэглэснээ Пильнякийн нэг номыг худалдаж авснаа хэлэв.

–Сайн зохиолч гэлцдэг юм гэж Михаил Юрьевич даруухан өгүүлээд, –Одоо сонирхолтой зохиолч олон болжээ. Зоценко, Бабель, Тынянов гээд... Гэхдээ Варенька минь, минийх шиг насан дээр бол хуучин танилуудтайгаа холбоотой байхыг илүүд үздэг юм. Номыг нь мэдэх зохиолчтой бол шалгарсан нөхөртэйгөө байгаа юм шиг санагдаж дахин унших бүрийд хүүхэд ахуй үе, идэр залуу насандаа эргэн очиж, бүх амьдралынхаа замаар аялдаг юм гэв.

Михаил Юрьевич заримдаа орон дороосоо юм уу ширээнийхээ араас тампуугаар таглаж боосон сагс татаж авчраад боодлыг нь задалж, дотроос нь мундаг урчуулын бүтээсэн бирга чимэглэлтэй, тансаг цаасан дээр хэвлэсэн “Мир искусств” (“Урлагийн ертөнц”), “Весы” (“Жин”), “Аполлон”, “Золотое руно” (“Алтан нэхий”) сэтгүүлүүдийг багц багцаар нь гаргаж ирнэ. Тэрээр,

–Энэ ч одоо хэзээ ч эргэж ирэхгүй биз дээ, уул нь бэлэгдэл мандан дэлгэрч, оросын урлаг хөгжин бадарч байсан үе... Бенуа, Сомов, Добужинский, Бакст... хэмээн гунигтай үгүүлдэг болой.

–Би бол “нүүдлийн зураачдад” дуртай, аргагүй л аугаа их урчууд, тэдний бүтээл хичнээн ч

жилийн нүүр үзэж байна даа, тэгэхэд ”Урлагийн ертөнцийнхнийг” бараг мэдэх хүнгүй болжээ гэж Варя хэлэв.

Михаил Юрьевич түүн рүү хавчдаг шилнийхээ цаанаас шагайн харав.

–Тэднийг одоо л тоохоо больж, сурталчлахгүй байгаа болохоос биш дээд зэргийн урлагтай дүрс зураг, уран гоё хээ хуар, нарийн нандин аяс гээд тэдний бүтээсэн гарцаагүй гавьяа бий л дээ.

“Урлагийн ертөнцийнхнийг” одоо мэдэх хүн байхгүй гэж Варя дэмий юм хэлсэндээ харамсав. Михаил Юрьевич гомдчихов бололтой.

–Михаил Юрьевич, би танайд хэдэн цагаар ч хамаагүй суумаар байх юм, та надаас залхдаггүй биз дээ.

–Хаанаас даа, огт үгүй! Таныг манайхаар орж гарахад би баярладаг шүү.

Тэрээр Сашаг дурсах нь элбэг.

–Саша бол уран сайхны ертөнцийн хүн. Гүндүүгүй цайлган сэтгэлтэй, бясалгах дуртай, гойд гярхай, уншсан юмаа эргэцүүлэн ярьж байхыг нь үзвээс нандин увдистай гэдэг нь илт байдаг юм. Гэвч цаг үе түүний зан чанарын идэвхтэй талаас нь хөтөлж, Саша байгалиас заяасан замаараа замнаагүй. Харин миний номын санг сайн ашиглаж, мөн ч их юм уншсан шүү.

–Саша ямар номд дуртай байсан бэ?

–Оросын сонгодог зохиол, ялангуяа Пушкиныг гаргууд сайн мэднэ. Пушкины зохиолоос бүхэл бүтэн хуудсаар нь цээжээр уншиж чадна. Толстой, Гоголь, Чехов, Салтыков-Щедрин энэ тэрийг сайн мэднэ. Достоевскийд дургүй.

–Би бас Достоевскийд дургүй, чацархай эргэчих шиг болдог юм гэж Варя өгүүлэв.

–Яваандаа дуртай болж ч магадгүй... За, Сашагийн тухайд гэвэл францын зохиолчдод, ялангуяа Бальзак, Стендаль хоёрт дуртай, тэр чинь францаар уншдаг шүү дээ.

–Өө тийм үү? Манай сургуульд герман хэл л заадаг байсан гэж Варя гайхан өчив.

–Саша дунд сургуулийг танаас таван жил орчмын өмнө төгссөн байх, тэр үед франц, герман хоёрын аль аль нь байсан юм. Хожмоо ганцхан герман хэл үлдсэн. Би франц хэл дээр муугүй номын сантай, тэгээд Саша францын зохиолчдыг эх хэлээр нь уншдаг байсан юм. Харамсалтай нь мань хүн хэлний сургуульд ороогүй, улс оронд инженер хэрэгтэй гэж үзсэндээ тэр. Гэхдээ түүнд тохиолдсон явдал амьдралынх нь замыг өөрчилж мэднэ. Зовлон эдэлснээр сэтгэлийн хараа хурдасаж, уран сайхны авьяас билэг хөгжинө, түүнээс гадна цөллөгийн дараа Саша олон нийтийн ажилд эргэж орох нь юу л бол.

–Түүний хэргийг дахин хянаж үзэж магадгүй, ер нь ямар ч буруу байхгүй юм чинь суллаж ч мэдэх юм.

Михаил Юрьевич эргэлзэн толгой сэгсрэв.

–Суллах ий? Тийм юм огт сонсож явсангүй. Хугацаагаа дуусгасан цагт нь суллавал л их юм болох вий.

–Тэр чинь юу гэсэн үг вэ? хэмээн Варя мэл гайхав.

–Суллахгүй байсан ч чадна, би тийм юм болж байсныг мэднэ, улс төрийн хэрэгтэнд хугацаа нэмчихдэг юм. Би тэгнэ гэж нотолж байгаа юм биш, гэхдээ үгүй гэхийн газаргүй гэж бодож байна. Манай орцонд Травкина гэж авгай бий, чи таних уу?

–Нэг удаа харсан. Би охиныг нь мэднэ.

–Та бага охиныг нь мэдэх юм байна, том нь бүр хорин хоёр оноос билүү дээ цөллөгт байдаг юм. Нэг бол Соловкид, нэг бол Нарымд. Ер нь эсер үзэлтэй, тэр үзлээсээ няцах бодолгүй учраас тэндээ байгаад байдаг биз. Сашад тийм явдал тохиолдохгүй байж болох л доо.

Михаил Юрьевич хавчдаг шилний цаанаас хялайдаг янзаараа Варя руу харав.

–Софья Александровнад үүнийг ярихын хэрэггүй шүү. Сашад элдэв учрал тохиолдохгүй гэж найдацгааж байя.

–Мэдээжийн хэрэг, би ээжид нь юу ч хэлэхгүй, хэлбэл ёстой алсантай адил болно. Сашагаа дахиж харах горьдлогоор л амь тээж яваа хүн, өөр бодох санах юм байхгүй.

–Тэгвэл сайн байна. Бид ч гэсэн бас хүлээцгээе. Саша буцаж ирээд байгалиас заяасан авьяасаа яваандаа хөгжүүлнэ. Улс төрийн бодлого явуулахад Саша дэндүү гүндүүгүй, итгэмхий зантай хүн, тийм ажилд өөр чанар хэрэгтэй. Дээд сургуулиас хөөгдчихлөөр нь эцэг рүүгээ юм уу нагац ах руугаа яваад өг гэж би зөвлөсөн, тэгсэн бол аврагдах байсан юм, түүнийг тэгээд л мартчих байсан. Гэвч шударга ёсонд үнэн санаанаасаа итгэдэг учраас миний үгэнд ороогүй, энэ бол түүний гүндүүгүй гэдгийн бас нэг нотолгоо шүү дээ.

Сашаг суллахгүй байж чадах нь уу?! Варя үүнийг сонсоод гайхахын цаагуур гайхжээ. Түүнийг дахиад хэзээ ч үзэхгүй гэж ёстой санаанд ороогүй билээ. Сашагийн өрөөнд, эд хогшлынх нь дотор, ээжийнх нь дэргэд аж төрж байхад түүний ийнхүү эзгүй байгаа нь түр зуурхны санаандгүй явдал шиг санагдана. Гэтэл хэзээ ч эргэж ирэхгүй гэж үү? Ямар мунхаг хэрэг билээ! Ёстой шударга бус, хууль бус явдал!

Тэгэх юм бол Софья Александровна яах бол оо? Хүүгийнхээ эргэж ирэх өдөр хоногийг хуруу даран тоолж, хүүгийнх нь захидлууд л амьдралынх нь гол үйл явдал болж байгаа хүн чинь. Ээжийгээ энхрийлэн хайрлах, урмыг нь сэргээн тайтгаруулах хүсэл сэтгэл бялхсан цэцэн цэлмэг үгтэй товчхон захидлуудыг Софья Александровна Варяд уншиж өгдөг билээ. Саша янз бүрийн зовлон тоочиж, ийм тийм юм явуул гэхгүй. Ойр ойрхон бичдэг боловч захидал нь тасалдаж ирнэ. Саша захидлаа дугаарладаг бөгөөд сүүлд бичсэн захидал нь түрүүлж ирэх нь бий. Ирээгүй захидлуудад нь ямар нэгэн чухал юм байсан учраас л ирэхгүй байна хэмээн Софья Александровна бүр зовчихно. Варя Сибирийн шуудан харилцааны зам ихээхэн

бэрхшээлтэйг дурдаж түүнийг тайтгаруулна. Нээрэн, хэлснээр нь болж нөгөө захидлууд нь хожим ирнэ.

Софья Александровна намар зам харгуй боогдохоос өмнө Сашад өвлийн хувцас хунар явуулахаар бэлтгэж, Варя тэр ажилд нь туслав. Сашад цөллөгт явахдаа өмсөөд явсан пальто, малгай хоёр бий. Софья Александровна түүнд эсгий гутал, хоёр хос дотуур ноосон өмд цамц, дулаан оймс, хүзүүний ороолт, ноосон цамц энэ тэр явуулахаар зэхжээ. Варя тэдгээрийг сарампай хайрцагт эвтэйхэн хийж, шуудан дээр очсон хойноо ноцолдохгүйн тулд гадуур нь таараар ороож оёод хортой харандаагаар хаяглав. Ийнхүү илгээмж бэлтгэж, шууданд тушааж явахдаа Софья Александровнатай хамт Сашаг яаж хайж, шоронгийн оочерт зовж зүдэрч байгаа хүмүүсийг анх үзэж харснаа дахин санах.

Саша “Арбатын нүхэнд” нэг хүүхнийг буруушаан муулж байснаа эмэгтэй хүнийх нь хувьд түүнийг яаж өмөөрснийг Варя бас нэхэн санажээ. Саша ердөө ийм л хүн. Нөгөө нэг Шинэ жилээр ч гэсэн Нинаг доромжлуулахгүй гэж тэр муу өлөгчингийн хүү Юра Шарокийг болгож тавьсан, тэгэхэд бусад нь тэвчээд юу ч дуугараагүй, харин мань хүн л хэлдгээ хэлсэн. Хуншгүй зан гаргахгүй гэснээсээ болж л Сибирьт оччихоод байна.

Ханын сониныг хэдүүлээ нийлээд л гаргасан, гэтэл мань эр бүх ялыг нь үүрч гарсан. Хуягуудын дунд дуулгавартай явж байл уу? Гэвч тэр маань яах байсан бэ? Зэр зэвсэггүй ганц хүн. Гэтэл нөгөөдүүл нь винтовтой гурван хун. Тэгэхэд мань эр Варяд арчаагүй амьтан шиг санагдсан. Яасан мунхаг вэ! Сашагийн хувьд оногдсон дөнгө түүнийг доромжлох бус, харин ч болбоос өргөмжилж байна. Варя элдэв янзын хүн олныг харсны эцэст үүнийг одоо ойлгожээ.

Ширээний нүдэнд Сашагийн дээд сургуулийн дэвтрүүд, үзэг, харандаа, бас унадаг дугуйнх юм болов уу, хэдэн эрэг шураг байна. Ширээн доогуур туухай, шүүгээнд номууд байна. Ном нь зөвхөн өөрийнх нь төдийгүй эцэг эхийнх нь байх, айлын номын сан хэдэн арван жилээр хуримтлан баяждаг шүү дээ. Тэглээ ч гэсэн Варя Сашагийн гэх номыг яг олдог байв... Жюль Берн, Фенимор Купер, “Толгойн эрлэг ахмад”, “Мөнгөн тэшүүр” - эд нар бол түүний хүүхэд ахуйн номууд, Дервиений 1912 онд хэвлүүлсэн Пушкины зургаан боть, Гоголийн нэг боть, Лермонтов, Толстойн “Дайн ба энх”, «Тиль Уленшпигель», “Калевала”, “Гайаватын дуулал”, Бласко Ибаньесын “Цус, элс”, Панаит Истратийн “Кира Киралина”, Ильф, Петров хоёрын зохиол, Зошенко, Бабель, Шолоховын номууд, Зөвлөлтийн Бага нэвтэрхий толь бичгийн арван боть.

Варя “Арбатын нүхэнд” бүжиглэж байхдаа яаж түүнд наалдаж байснаа саналаа. Шинэ жилийг угтахад бас л наалдаж байсан, энэ тухай дурсан бодоход одоо ч гэсэн сэтгэл догдлох ажээ. Саша өөрт нь мэдээж сайхан санагддаг байсан, түүнд бүр сэтгэлтэй болчихсон байж ч магадгүй, гэвч түүнийг том хүн гэж бодоод сурчихсан тул дурласан мэтийгээ ойлгодоггүй байж. Үгүй ээ, ойлгодог байсан, тийм ч учраас түүнтэй хамт гулгаж, гараас нь барьж байх гэж мөсөн гулгуур луу очье гэж билээ...

Саша захидал болгондоо өөрт нь мэнд уламжилна. Захидлын эцэст “Варяд мэнд дамжуулаарай” гэсэн гурван үг байна. Эелдэг ёсыг бодож бас Софья Александровнатай сайн байдгийг нь бодож тэгдэг байж болох юм. Гэхдээ мэнд дамжуулахдаа ганцхан Варяг нэрээр нь нэрлэж, бусдад нь “Төрөл садан болон бүх танилуудад мэнд дамжуулаарай” хэмээн бөөнд

нь нэргүй биччихнэ. Энэ бүхэнд ямар нэг дутуу хэлсэн юм шиг хэрнээ Саша тэр хоёрт хоёуланд нь ойлгомжтой аль нэг дорвитой санаа байх шиг Варяд санагдана. Тэрээр өөрөөс нь бас мэнд дамжуулж байхыг Софья Александровнагаас гуйдаг билээ.

–Чи өөрөө хэдэн үг биччихээч гэж Софья Александровна нэг удаа хэлжээ.

Гэвч Варя хараахан захиа бичихдээ хүрээгүй байв. Хэдэн хоосон үг бичнэ гэхэд ичгүүртэй, “түргэн ирээрэй” гэж бичье гэхэд тэр нь өөрөөс нь хамаарахгүй учраас тэнэг зүйл болно. Ямар нэг дорвитой зүйл бичиж өөрийнх нь тухай бодож, өөрийг нь санаж байдгаа ойлгуулах зүрх арай байсангүй.

Тэгээд,

–Би юу бичих вэ дээ? Ажлын газрынхаа тухай бичилтэй нь биш. Тийм юм түүнд яаж сонин байх вэ дээ? хэмээжээ.

Михаил Михайлович Маслов дээр Ольга Степановна гэдэг авгай нь ирэв. Калининаас Красноярск хүртэл галт тэргээр, Енисей мөрнөөр усан онгоцоор явж, дараа нь замын завиар Ангарыг өгсөн харгиа боргио гаталж иржээ. Нөхөртэйгөө гуравхан хоног уулзахын төлөө ийм зам туулсан хэрэг.

Найрсаг харцтай, намбалаг хөдөлгөөнтэй нүдэнд дулаахан авгай. Тэр хоёр долоон жил нэг нэгийгээ хараагүй ажээ. Хоёр хүүхэдтэй. Хэзээ, хаана ямар нөхцөл байдалд гэрлэсэн юм бол? Нөхөр нь хуучин цэргийн дарга, эхнэр нь нягтлан бодогч.

Саша авгайг харж байснаа гэнэтхэн Михаил Михайловичийг залуухан сайхан эр байсныг тов тодхон төсөөлж, дэргэд нь баяр хөөр, итгэл найдвар гэрэлтсэн идэр залуу Ольга Степановна харагдаж, царайд нь аз жаргал туяарсан гоолигхон хоёр хос нүдэнд нь дурайгаад явчихжээ. Бас аймшигт долоон жилд багтсан тэдний жинхэнэ амьдралыг хамаг нарийн ширийн юмтай нь нэгд нэгэнгүй тов тодхон харлаа.

Ольга Степановна өглөө шуудангийн завиар ирсэн атал Михаил Михайлович тэр орой нь бүх хүнийг преферанс тоглоё гэж урив. Энэ гурван өдрийг Михаил Михайлович, Ольга Степановна хоёр хоёулхнаа ханиндаа өнгөрөөнө гэж Саша санаж байсан тул тийнхүү хөзөрдье гэсэнд яльгүй гайхжээ. Шинэ хүн, ялангуяа чөлөөт хүн ирнэ гэдэг бол энд чухал үйл явдал, гэлээ ч гэсэн... Өдий жил уулзаагүй, дахиад төдийчинээ хугацаагаар уулзахгүй байж магадгүй байхад мань хүн хөзөр тоглоё гэж байх.

Михаил Михайлович авгайтайгаа ярихдаа яаж уцаарлан тээршааж байгааг үзээд Саша бүр ч гайхаж хоцров. Энэ нь түүний ердийн нэг хор шар биш, зориуд турхирсан адайр хэдэр ааш даруй мөн бөгөөд хүйтэн харц нь улам хэрцгий догшин болох янзтай.

Авгай нь тоглоомд оролцолгүй нөхрийнхөө дэргэд хөзөр лүү нь хараад чимээгүй сууж байгаа боловч тоглож чаддаг нь илэрхий аж. Тэгээд Михаил Михайловичийг нэг удаа буруу хөзрөөр явахад,

–Хөзөр биш модоор явсан бол дээр байхгүй юу гэж цорын ганцхан удаа дуугарав.

Михаил Михайлович татвасхийн,

–Битгий заагаад байгаарай! Яаж тоглохоо би өөрөө мэднэ гэв.

–Би заасан юм биш ээ, наад тавил чинь дуусчихсан хэмээн авгай нь нөхрөө уучлахын хамт амьдралын эрхээр ааш нь эвдэрсэн энэ хүнийг уучилж үзэхийг бусдаас мөн царайчлах мэт номойхон инээмсэглэв.

Цөмөөрөө эвгүй байдалд орцгоов. Пётр Кузьмич хоолой засан, Всеволод Сергеевич өөр яриагаар дүйвүүлж, гагцхүү Сашагийн л уур дүрсхийсэн боловч биеэ барьж босоод тооцоогоо бодохыг хүсэлт болгов.

Всеволод Сергеевич Сашатай хамт яваад өглөө. Саша харих замдаа,

–Маслов - мал! Эмэгтэй хүн өөрийг нь бодож ийм зам туулж, ханийн тангарагтаа үнэнч байхад түүний тэр ярьж байгаа царайг нь гэж бухимдав.

–Нээрэн, биеэ хайрладаггүй хүүхэн байна хэмээн Всеволод Сергеевич ам дагуулснаа нөгөө жогтой янзаараа инээмсэглээд, –Харин ханийн тангарагтаа үнэнч эсэхийг бид мэдэхгүй шүү гэж нэмж өгүүлэв.

–Завхай хадмын бэр хэзээд...

–Та намайг хэлж байна уу? гэж Всеволод Сергеевич инээхчээн аядав.

–Таныг.

–Та намайг муу мэднэ хэмээн Всеволод Сергеевич зөрж, –Ольга Степановна ингээд хүрээд ирснийг би их тоож байгаа шүү. Гэхдээ түүний Калининд яаж амьдардаг тухай бодоод үз л дээ. Ганц бие залуухан гоё хүүхэн... гэв.

–Та адгийн муухай юм ярьж байна.

–Саша, та бол дэврүүн сайхан бодолтой хүн, тэгж яривал чухам энэ учраас би танд хайртай байдаг юм. Таны энэ гэнэн занд анхны нөгөөдүүлийн биеэ умартах сэтгэлээс ямар нэг юм байх шиг... Ольга Степановна бол аргагүй л өгөөмөр шинжийн хүн, тийм хүүхэн бол дээд зэргийн хүүхэн мөн. Гэхдээ түүнийг хоёр хүүхдийн ээж, ажил хийх ёстой хүн гэдгийг мартаж болохгүй. Гэтэл манай нөгөө ажил хайрлагч чинь эсэргүүчүүд, тэдний авгай хүүхдийг эрхлүүлэхгүй шүү дээ. Тэгээд л юм бодоход хүрч байгаа юм даа, эрхэм Саша минь! Ялангуяа хүүхдүүд хоол нэхээд ирэхийн цагт, зүгээр ч үгүй өдөрт нэг удаа биш гурван удаа нэхэх цагт арга буюу л юм бодно. Эрхэм та, одоохондоо жинхэнэ амьдралыг мэдэхгүй, үүлэнд хөвсөн чигээрээ явж байна гэж Всеволод Сергеевич хор шаргүй өгүүлэв.

–Ямар ч нөхцөлд тэвчих ёстой зүйл гэж бас байна. Ольга Степановнаг ямар нэг юман дээр тэвчээр алдсан гэж нотлох үндэс танд байхгүй.

–Би тэгж зүтгэж байгаа юм биш, зүгээр л байж болох зүйл гэдгийг хэлж байна.

–Тэгж хэлэх ч үндэс танд байхгүй. Бид ганцхан юм л мэдэж байна. Юу вэ гэвэл, Ольга Степановна Масловыг хаяагүй, түүнээс урваж няцаагүй, өөр хүнтэй суугаагүй, түүнийг харах гэж л ийм зам туулсан, гэтэл цаадах нь түүнтэй хүний үнэргүй харьцаж байна.

–Нээрэн, хүмүүжилгүй хүн шиг зан гаргасан шүү. Би тэгээд л учрыг ойлгох гэж оролдож байна гэж Всеволод Сергеевич өгүүлэв.

–Ойлгож ядах юу байгаа юм бэ, хүний адаг л байна хэмээн Саша тамшаалснаа, –Манай нөхцөл хүүхнүүдийг муу явдалд албадан оруулж байна гэж та ярьж байна. Тэгвэл ямар нөхцөл Масловыг хүний адаг болгож байгааг хэлж өгөхгүй юу? Хамаг юмыг Зөвлөлт засаг руу битгий чих, Зөвлөлт засаг үүнд чинь огт хамаагүй. Маслов авгайнхаа номой даруу

байдлыг ашиглаж байна, аливаа даруу хүн хүний мөсгүй, бүдүүлэг этгээдийн дэргэд заавал дорой байдаг шиг авгай нь Масловоос дорой байгаа л даа гэв.

–Саша, би таныг бүр гайхаж байна, танай үеийнхэнд зохихгүй ухагдахуун танд хоцорсон байх юм. Чухам үүнээс болж ийшээ ирчихсэн юм биш үү? Та ер нь ийм хүн үү, эсвэл энд ийм болчихов уу?

–Надад нөхдөөсөө ялгаатай юм ор байхгүй, та л биднийг огт мэдэхгүйдээ тэгж байгаа юм. Ленин үүрдийн үнэнийг бас үгүйсгэдэггүй байсан, өөрөө ч тийм үнэнээр хүмүүжиж бойжсон. Ангийн онцгой ёс суртахууны тухай түүний хэлсэн зүйл бол цаг үеийн шаардлагаас гарсан хэрэг, хувьсгал гэдэг бол дайн, гэтэл дайн бол хэрцгий үзэгдэл. Гэхдээ манай үзэл санаа бол мөн чанараараа үнэхээр хүнлэг. Лениний хувьд арга барагдсан хэцүү байдалд үүссэн түр зуурын зүйлийг Сталин үүрдийн заяаных болгож номлол болгон өргөмжилж байна гэж Саша өгүүлэв.

–Сталины тухай та юм яриагүй, би сонсоогүй болцгооё хэмээн Всеволод Сергеевич дахин инээж, –Харин Масловын тухайд гэвэл та дэндүү бүдүүвчилж байгаа вий. Амьдрал бол нарийн төвөгтэй зүйл, ялангуяа Маслов шиг хүнийх бол ямар ч хэв загварт таарахгүй. Та хэдийгээр ариун шударга зантай ч гэсэн танд нэг арилаагүй хий байна. Та бут үсэрсэн итгэлийнхээ өөдөснүүдийг зүйж өөр сав суулга хийх гэж оролдож байна. Өөдөснүүдийг гагцхүү хуучин дүрсээр нь эвлүүлж болдог учраас тэр чинь бүтэшгүй ажил. Нэг бол өөрийнхөө итгэлд буцаж үнэмшинэ, нэг бол түүнийг хөсөр таягдан хаяна.

Тэр хоёр Всеволод Сергеевичийн гэрийн гадаа салцгаав.

Саша Зидагийн цонх гэрэлтэй байхыг харав. Өөрийг нь хүлээж байгаа нь тэр. Тэрээр голдуу голын тэндээс тэдний рүү очдог тул доошоо буулаа. Гэвч тэднийд очмооргүй байв. Хайр сэтгэл баяр цэнгэл авчирч, амьдралын чимэг болдог... Харин амьдрал байхгүй бол ямар ч хайр сэтгэл түүнийг чимж чадахгүй.

За яахав, эрэг дээр жаахан сууя, дараа нь очиж ч магадгүй. Саша ойрдоо голын ус, голын усанд туссан сарны мөнгөн туяаг ширтэн эрэг дээрх завин дотор суух нь элбэгшжээ.

Зидагийн дэвшүүлж байгаа санал бол асуудлыг шийдэх арга биш. Энэ хүүхэн яльгүй юманд сэтгэл ханаж яваа нь түүний сайн тал, гэхдээ яагаад ийм бөглүү газар суугаад байна вэ? Ер нь хэн гээч вэ? Нэг хүнээс ч юм уу, эсвэл нэг юмнаас ч юм уу нуугдаж, газрын мухарт бүгчихээд өөрийг нь бас тэгж жоом шиг бүгүүлэх санаатай байна. Үгүй ээ, түүнд жоом шиг аж төрөх бодол алга. Түүнийг жоом болгож чадахгүй.

Хүний хөлийн чимээ сонсдов. Зида хүрээд ирлээ гэж үү дээ?

Доогуур хөшиглөсөн үүлний цаанаас саран авхай хаа нэгтэй шагайна. Голын хөвөөгөөр явж байгаа хоёр хүний дүрс Сашад бүүр түүрхэн харагдаж, яг тэрүүхнээр нь өнгөрөх үес Маслов, Ольга Степановна хоёр болохыг танив. Тэр хоёр Сашаг хараагүй учраас хэдэн шон дээр өлгөсөн торны цаана очоод зогсоцгоов.

–Ольга, миний үгийг сонс, би чамаас гуйя... Саша яах учраа олохгүй болов. Тэр хоёрыг цаашаа яваад өгнө гэж бодоод шууд босоогүй, гэтэл нөгөөдүүл нь ойрхон зогсчихсон болохоор одоо босож тэдний яриаг сонсож байгаагаа мэдэгдэх нь эвгүй юм. Михаил Михайлович яриагаа үргэлжлүүлэв.

–Чи намайг ойлгож үз, гуйх юм энэ л байна, надад өөр арга алга. Намайг бүрмөсөн хая, амьдралаасаа сох хас, хүүхдүүдээ бодож, өөрийгөө бодож надаас няцаж үз. Хүнтэй суугаад өөрийнхөө овгийг, бас хоёр хүүхдийнхээ овгийг сольчих, миний нэрнээс л салж ангижир. Та нарт надтай хамт балрахын хэрэг юу байна? Би хүүхэд та нарыгаа бодоод хэдэн шөнөөр нойргүй хонодог юм. Чамайг ажлаас чинь хөөгөөд цөлчихнө. Намайг тийм зовлонд бүү унага! Би насгүй болсон хүн, гэхдээ сэтгэл амар үхэхийг хүсэж байна. Хүүхэд та нар минь айх аюулгүй болсон гэдгийг мэдэж байж үхэх ёстой.

–Ээ бурхан сахиус минь, чи яаж ийм юм ярьж зүрхэлнэ вэ?!

–Би амьдралгүй хүн, юу ч ярьсан чадна. Чи яах гэж ирэв ээ? Тэндээ очсон хойноо юу гэж тайлбарлах юм бэ? Чамайг надаас салахыг зөвшөөрч байгаагаа бичгээр баталгаа хийж өгье, чи тэгээд зөвхөн ийм баталгаа авах гэж явсан гэж хэлээрэй. Ял заагдсан хүнээс салахад баталгаа хэрэг байдаггүй юм, гэхдээ чи тэр тухай мэдэхгүй, хэрэгтэй юм байх гэж санаад явчихсан болно биз.

–Би чамайг зовоож байгаа биш, харин чи намайг зовоож байна. Явья, би даарч байна гэж Ольга Степановна өгүүлэв.

Тэгж тэгж гэрээс нь захиа ирлээ. Зүгээр ч үгүй Всеволод Сергеевичийн яг мэргэлсэн ёсоор найман захидал бөөндөө ирэв. Ээж нь тэдгээрийг өдөр алгасахгүй бичиж, цөмийг нь Богучанын хаягаар илгээсэн ажээ. Саша захидлуудаа дугтуйн дээрх явуулсан сар, өдрөөр нь дугаарлан дэлгэж тавиад тэр дарааллаар нь уншив. Ээж нь өөрийнхөө тухай бараг бичсэнгүй: “Миний бүх юм сайн байна, ажлаа хийж байгаа, ажил дээр ч гэсэн бүх юм сайн байна”. Эцгийнх нь тухай огт дурссангүй, тэгэхлээр ээжийг нь бүр орхисон хэрэг, Маркийн тухай ч юу ч алга, Москвад ирэхгүй байгаа юм байлгүй, Нина болон бусад найз нарынх нь тухай юм бичсэнгүй, тэд нар орж гардаггүй гэсэн үг, эгч дүү хоёроо дурдсан, тэднийхний бас бүх юм сайн гэнэ. Захидалд байгаа гол юм нь асуултууд: “Бие чинь ямар байна, яажшуухан төвхнөв, хоол унд ямар байна, юу хэрэгтэй байна, заавал бичээрэй, битгий нэрэлхээрэй, бид чамд юу ч байсан олж явуулна”. Ээж нь гагцхүү өөрийг нь бодож, гуньж гутарч, зовж шаналж байгаа гэдэг нь илэрхий ажээ. Гэхдээ ээж нь шантарч мохолгүй тэвчин даваад өөрийнх нь төлөө аж төрж байна, тэгэхлээр өөрөө ч гэсэн ээжийнхээ төлөө амьдрах ёстой, өөрийг нь амьд байгаа цагт ээж нь амьд байна гэсэн үг. Түүнээс гадна захидал болгонд Варяг дурдсанаас үзвэл ээж нь ганцаардаагүй юм байна. “Варя бид хоёр чам руу хамт очиж байсан” хэмээсэн нь тэр хоёр ханиндаа түүнийг хайж шорон хэссэн гэсэн үг. “Варя бид хоёрыг оочерт зогсож байхад” гэснийг үзээд тэд нар ямар оочерт зогсож байсныг Саша төвөггүй ойлгож байв.

Бүх нөхөд нь түүнийг орхижээ. Харин ганцхан Варя, нөгөө бяцхан Варя л ээжийг нь орхиогүй байна. Саша түүний шингэн тунгалаг царай, давхраатай нүд, огцомхон дух руу нь эвлэгхэн унжсан үс, арван таван настай хөөрхөн охидын багачуулыг ичээдэг харц, сургуульд байхдаа “будаагаа” бичдэг байсан нүцгэн өвдөг энэ тэрийг дурсан санахад бяцхан гоолиг

хүүхэн нүднээ бууна... Захыг нь хайш яйш босгосон хар пальтотой Варя яг өөр шигээ охид хөвгүүдийн хамт хорооны үүдэнд ямаршуухан байдалтай зогсож байдгийг нэхэн санана. “Арбатын нүхэнд” сууж байгаадаа яаж баярлаж байсныг санана, түүнтэй яаж бүжиглэж байснаа санана... “Цэцэглэх хаврын цагт хаа ч хэсүүчилж явсан, цэцэн зүүдний ачаар чамтайгаа золгож байнам...” Толгой эргүүлэх маягийн томоогүй хэдэн юм хэлээд өөр лүү нь яаж наалдаж байсныг бас санана...

Ганц Варя л ээжийг нь зөнд нь орхилгүй, хамгийн хэцүү бэрх өдрүүдэд түүнд хань болж байжээ. Чухамхүү тийм айх шантрахыг мэдэхгүй хүн л ээжид нь хэрэгтэй байсан юм. Ямар ачтан тийм түшиг явуулаа вэ? Энэ эрэлхэг охиныг энхрийлэн хайрлах сэтгэл Сашаг өөрийн эрхгүй эзэмдэв. Гэтэл мань хүн тухайн үедээ түүнийг Нинагийн нүдээр харж сургаал айлдаж байсан билээ. Тэгэхэд мань хүн хичнээн явцуухан үзэл бодолтой байж вэ?

Өөрийнх нь орцонд Травкина гэдэг эмгэн бага охинтойгоо аж төрдөгсөн. Том охин нь эсер билүү, меньшевик билүү, Соловкид байдаг гэсэн. Тэднийхэнтэй мэндийн зөрөөтэй хүн байгаагүй. Хар пальтотой, хуучин хийцийн мөн хар бүрх малгайтай туранхай цэх эмгэн хашаагаар орж гарахдаа дуу шуугүй өнгөрнө. Бага охин нь бас л дуу шуугүй өнгөрнө. Түүний сэргэлэн харцнаас арга барагдан царайчилсан янз мэдэгдэх боловч тэрээр тааралдсан хүмүүсийн харцнаас эсвэл хайхрамжгүй байдал, эсвэл тавласан байдал олж үздэгсэн.

Саша ч гэсэн түүнийг дайсны ар гэрийнхэн хэмээн жигшин нүд үзүүрлэдэг байсан.

Одоо ээж нь дайсны эх учраас хашаагаар орж гарахдаа яг тийм харцны бай болж байгаа. Гэтэл ээжид нь Варя хань болж, гай түйтгэрийг нь хуваалцаж, зовлонг нь хөнгөлж байгаа болохоор ганцаардахгүй байгаа.

Шуудан долоо хоног бүр ирнэ. Саша заримдаа захиатай, заримдаа цагаан даавуугаар боож оёод хүрэн лацаар тамгалсан илгээмжтэй, заримдаа цавуу нь шарлан хатсан боодлын цаасаар жимбийтэл ороосон боодолтой гэртээ ирнэ. Боодол дээр нь мэдээж Варя л бичээ л дээ, шугам зургийн тод үсгээр “Канскийн тойрог. Кежмагийн район, Мозговая тосгон” гэж дурайтал бичсэн байна. Захиан дээр бичсэн хаяг нь яг адилхан. Саша ээждээ “Мозговая биш Мозгова” гэж залруулсаар байдаг боловч ээж нь өөрийнхийгөө зөвд тооцож тийнхүү бичсээр байгаа ажээ.

Саша баяр хөөрөө уртасган сунгах үүднээс захидлуудаа гүйлгэн харж, сонинуудаа гарчиглаж, аль сонирхолтойг нь гүйцэд уншсаны дараа хойш нь тавиад илгээмжээ нээнэ. Жигнэмэг, чихэр, какао, хатаасан буюу нөөшөлсөн жимс... Энэ бүхэн маш их үнэтэй. Хүнсний зүйл явуулахыг Саша хориглосон боловч ээж нь ирүүлсээр л байна.

Саша бүх юмаа үзэж, ямархан баяр жаргал эдлэхээ төсөөлж гүйцсэний дараа нөгөө бүтэн долоо хоног хүлээсэн баяр цэнгэл нь сая эхэлнэ. Одоо бол захидлуудаа тогтуухан бөгөөд анхааралтай эргэж уншина. Ээж нь он, сар, өдрөө тавьж захидлаа дугаарлан өдөр бүр үргэлжлүүлэн бичсэн байна. Захидал нь тэр бүрий дугаар ёсоороо ирэхгүй. Захиа болгонд Варя мэнд уламжилсан байна, өөрөө захиа бичихгүй гагцхүү мэнд уламжилна. Яагаад тэр вэ? Саша өөрөө ч гэсэн түүнд мэнд л уламжилдаг байснаа нэг удаа ээждээ явуулах захидалд “Варя минь, чи их ач тус болж байна, ёстой гялайлаа” гэж нэмж бичжээ. Ингэсний дараа

захиа бичиж магадгүй гэж бодсон аж.

Саша захидлуудаа уншчихаад сониноо барьж авна. Энэ ажлыг хоёр өдөр сунган хужирхайгаа тэнийлгэж, хэрвээ сэтгүүлүүд ирсэн байвал бүр долоо хоног жаргалаа эдэлнэ. Сонинууд нь хүний гар дамжчихсан учраас Москвад Арбат, Полтников гудам хоёрын уулзвар дээр байдаг мухлагийн өглөө эртийн сонин шиг хэвлэлийн шинэхэн будаг эс ханхална. Заримдаа аль нэг дугаар дутуу таарахад Саша урам хугаран гонсойдог боловч ээж нь өөрийнх нь төлөө чадах бүхнээ хийж байгаа учир түүнд яахан гоморхох билээ, сэтгэлээ тэвчин барина. Ингэж урам хугарна гэдэг бол тэсвэр тэвчээргүй өссөнийх. Ээжийнх нь салан зан ар гэр, хүүхэд ахуй цагийг нь бодогдуулж энэ нь ч чухамдаа тэр дутуу сониноос илүү эрхэм олз болой.

Арбатад трамвай явахаа больж гудамжийг хуу цардсан гэнэ. Арбатад трамвай байхгүй болсон гэхэд Сашагийн толгойд нэг л сайн бууж өгөхгүй байв. Арбатын талбай дээр метроны буудал барьсан гэнэ, өөрийнхөө нүдээр харах юмсан... Төлөвлөгөөт таван жилийн хоёр дахь он. Үйлдвэрийн дамжлагаас автомашин, трактор хөвөрч, домна, мартен зуухнаас ширэм, ган урсаж, хүмүүс урам зоригтой ажиллахын үлгэр жишээг үзүүлж байхад түүний зэрэгцээ тоо томшгүй шүүн таслах ажиллагаа явагдаж, залхаан цээрлүүлэх байгууллагуудыг бэхжүүлж байна. Хилийн чанад руу зугтвал буудан алах ял заахын хамт ар гэрийнхэнд нь арван жил хорих ял оноохоор тогтоожээ. Хийгээгүй хэргийн төлөө хариуцлага хүлээлгэх нь. Энэ бүхнийг ганцхан хүний эрх ашгийг бататгахын тулд хийж байна. Гэтэл энэ хүн нь шинэ амьдралын бэлэг тэмдэг, ард түмэн юунд итгэж, юуны төлөө тэмцэж, юуны төлөө зовж байгаа билээ, тэр бүхний бэлэг тэмдэг билээ. Тэгэхлээр түүний нэрээр хийгдэж байгаа бүхэн шударга зүйл байх нь уу?

Эцгээс нь захидал ирэв. “Захиа бичихгүй удсаныг уучлаарай, чиний хаягийг авч чадахгүй байсан юм” хэмээсэн нь хүүгийнхээ тодорхой хаягийг хүртэл хэлээд өгчихөж чадахгүй арчаагүй амьтан гэж ээжийг нь бахь байдгаараа муучилж байгаа царай нь тэр. Тэрээр ээж нь Сашагийн хаа байгааг мэдэхгүй байх ёс байхгүй гэж итгээд хаягийг нь мэдэхгүй байсныг эцэг хүү хоёрыг хөндийрүүлэх гэсэн оролдлого гэж үзжээ. Энэ бол Саша ухаан орсон цагаасаа сонссон үй олон зэмлэлийн нэг билээ.

Эцэг нь захидалдаа Сашаг бүрхэн нөмөрсөн гай зовлонгийн анзааг ойлгож байгаа, гэхдээ Саша залуу хүн, хамаг амьдрал нь урд нь хүлээж байгаа, бүх юмны ая олодоно, сэтгэлээр унахын хэрэггүй, тэдний гэр бүлийн доторх харилцаа ийм болсон нь өөрийнх нь буруу биш, гэхдээ энэ харилцаа ямар ч байлаа гэсэн тэрээр өөрийнх нь эцэг төдийгүй жинхэнэ үнэнч нөхөр нь гэдгийг Саша мэдэж байвал зохино гэхчлэн бичжээ.

Саша захидлыг хажуу тийш нь тавив. Эцэгтэйгээ тааралдах бүрийд сэтгэлийнх нь тав алдардаг лугаа адил хачин оргиод явчихлаа. Эцэг нь хэзээ ч Сашагийн амьдралыг сонирхож байгаагүй, ер нь түүний санаж сарвайдаг ганц юм бол амин хувийнх нь амьдрал. Мань хүн Сашаг бүрхэн нөмөрсөн гай зовлонгийн төлөө санаа зовоходоо хүрсэн нь үнэн бол гагцхүү энэ явдал түүний амьдралд төвөг удаж, дассан дэг журмыг нь эвдсэнээс л болсон хэрэг, яагаад гэвэл дэг журам гэдэг бол түүний амьдралын философи бөгөөд гол утга учир юм.

Сашаг бага байхад эцэг нь түүний өрөөнд орж ирж гэрэл асаан Сашаг сэрээгээд солгой талаараа хажуулдаж унтах хортой, багаасаа зөв унтаж сурах хэрэгтэй хэмээн зөв тал руу нь

эргүүлж хэвтүүлдэг байжээ. Бүх юм байр байрандаа байх ёстой хэмээн ширээн дээрх Сашагийн ном, дэвтрийг эмхлэн нямбай гэгч нь хурааж тавина. Түүнчлэн бүх юмаа орой нь цэгцэлж бэлтгэх хэрэгтэй, хүн чинь өглөө ажилдаа яаравчилдаг юм, энэ мэтийг ч гэсэн бас л хүүхэд цагаасаа сурах хэрэгтэй гэнэ. Саша нойроо харамлахын хажууд эцгийгээ өрөөндөө удаахгүйн тулд хэлснээс нь зөрөхгүй, ер нь ч зөрөөд нэмэр байхгүй, эцэг нь чих хатуу болохоор дахин дахин асууж, Сашаг зориуд аяархан ярьж байна гэж дотроо итгэж байгаа учир уцаарлаж бүр хэрэг мандана.

Дэг, дэг, дэг! Тэрээр өөрөө нь ч дэгээ нарийн барина, бусдыг ч яг тэгж сахиулах гэж шахна. Гэртээ ч бай, гадаа ч бай, ажил дээрээ ч бай, бухимдаж уцаарласан нэгэн түрэмгий ёсорхог этгээд. Түүний шинэ бүтээл, оновчтой санал гаргах үйл ажиллагааных нь гол сэдэв бол “Үйлдвэрлэлийн алдагдалтай хийх тэмцэл” юм. Үйлдвэрлэлийг амжилттай явуулахын үндэс бол (тэрээр хүнсний технологич байсан юм) ариун цэвэр. Ариун цэвэр гэдэг бол бас бие бялдрын болоод зан суртахууны хувьд эрүүл байх үндэс, шударга түвшин байхын үндэс, урт удаан наслахын үндэс. Заваан хүн шударга түвшин байна гэж ном байхгүй! Дэг журам, ариун цэвэр, эрүүл ахуй! Жимсийг хүнсний ногооны адил усаар хэд дахин угаах хэрэгтэй, тэгээд хэдийгээр хальсанд нь ашигтай шим тэжээлтэй бодис байдаг ч гэсэн хальсыг нь цэвэрлэх хэрэгтэй. Тэрээр алимыг зугуухан маш нимгэн хальслаад, мөн тийнхүү зугуухан иднэ. Хоол идэхдээ анхаарлаа төвлөрүүлэн маш нямбай зажилж бүртийх ч юм үлдээлгүй иддэг агаад бяцхан Сашад бас юу ч үлдээхгүй идэхийг тулгана. Юу ч дэмий үрэгдэх ёсгүй, тавган дотор юу ч үлдэх ёсгүй!

Тэрээр нэг авсан гутал хувцсаа арав хорин жилээр өмсөнө. Шаахайгаа сэврээх гэж шөнө болгон цонхны тавиур дээр хонуулна. Тийш нь тавихынхаа өмнө үүдний зайд тосолж цэвэрлэнэ. Зай умгарыг ч хэлэх үү, эцэг нь шалан дээр сонин дэвсэж, шаахай, сойз, тос энэ тэрээ хавийн нэг дэлгэж хэн хүнгүй саад болдог бөгөөд үүнийгээ мэддэг тул юу гэж хэдэрлэхээ эртнээс бэлтгэнэ. Түүнтэй хэл ам сөрөхийг хүсэх хүн байхгүй учраас хэн ч түүнийг шүргэж тээр болохгүй. Харин өчүүхэн төдий ч дэг алдсан байсан мань хүн өөрөө дуугүй өнгөрнө гэж нүгэл. Жорлонгийн гэрэл унтраагаагүй буюу онгоцны өрөөний гоожуурыг дутуу хаасан байлаа гэхэд гэрээр нэг дүрэмдэн хашгична. Айл хөршийнхөн цөм өрөө өрөөндөө дуугаа хураан сууцгаавч эцсийн бүлэгт хэн нэгнийх нь тэвчээр барагдаж үүдэндээ гарч ирээд чухам хэнийг хэлээд байгаагаа нэрээр нь хэл гэж шаардана. Тэгээд бие биеэ өөлж баахан маргаан шуугиан дэгдэнэ.

Гэр орны нөхцөлд тэсэхийн аргагүй энэ утга учиргүй сүржин ёсорхог зан бол хөдөлмөрийг эрхэмлэн хүндэлдэг зангийнх нь өрөөсөн тал нь билээ. Тэрээр өөрийнхөө ажилд дуртай, нарийн мэргэшилтэй, сайн ажилтан төдийгүй гаргууд ажилсаг бөгөөд бусад бүх хүнийг лазан хойрго, үл бүтэх этгээд хэмээн дарга нартайгаа ам муруйж, хамт ажилладаг хүмүүстэйгээ толхилцоно.

Ажил, шинэ бүтээл, оновчтой саналаас өөр бодох санах юм гэж юу ч байхгүй, ярьдаг юм нь ч зөвхөн тэр. Саша түүнийг өрөвдөж, ам хэлээ ололцохыг оролддог боловч ерөөсөө бүтэхгүй, түүнтэй ярилцана гэдэг бол тэсвэрлэх эд биш. Ажил дээрээ тохиолдсон элдэв зохисгүй хэрэг явдлын тухай ярихдаа өөрийнхөө дайсныг Сашагаар бас үзэн ядуулах гэж зүтгэнэ. Саша үл мэдэх олон хүний овог нэрийг сонссоор толгой нь дүйрч, өөрийн эрхгүй ”тэр чинь хэн юм

бэ?” гэж асуухад эцэг нь “Би түүний тухай ноднин чамд ярьж байсан шүү дээ, гэвч эцгийн чинь ажилд чамд ямар ч пад алга!” гэж уурлана.

Саша хүнсний аж үйлдвэрийн техникийн нэр томъёог мэдэхгүй атал эцэг нь бичсэн өгүүллэгүүдийнхээ найруулгыг засуулах гэж түүнд өгнө. Тэгээд учрыг нь хэлээд өгөхийн оронд “Ийм амархан ойр зуурын юмыг тогтоочиход хэцүү байна гэж үү” хэмээн зүхнэ. Саша түүний бичсэн зүйлийг уншихаас зайлсхийж тэгснээр тэр хоёр улам хөндийрөхөд хүрнэ.

Тэр байрны суугч болгон гэртээ орж ирэхдээ янз янзын зуршилтай. Галя хаалга савчихаад үүдний өрөөгөөр гүйх нь халаг хурдална, Михаил Юрьевич бараг чимээ аниргүй аятайхан, зөөлхөн орж ирнэ. Гэтэл эцэг нь хоёр дахь хаалгыг дугуу хаасан байна, байрны дулаан гадагшаа гарчихлаа, хөлийн алчуур байх газраасаа хөдөлчихсөн байна, энэ алчуур саад болоод байна гэж үү дээ, яасан хачин улс вэ гэхчлэн заавал нэг болохгүй юм олж харж, цоожны нүхэн дотор түлхүүрээ түжигнүүлэн уцаарлана.

Өрөөндөө муухай царайлан орж ирээд өглөө бараагаа харалцаа биз дээ гэсэн шиг мэндийн ч зөрөөгүй гэр орноо эргүүлдэн харж эмх замбараагүй байгаа юм хайх боловч эх нь түүнийг ирэхийн өмнө хамаг юмаа сайтар эмхлэн цэгцэлдэг тул нүд үзүүрлэх юм эс олно. Юу ч ярилгүй хувцсаа тайлж, пальтогоо хувцасны шүүгээнд мөрөвчинд өлгөж, пиджакаа сольж гэрийн хүрэм өмсөөд гар нүүрээ угаахаар угаагуурын өрөө рүү очиж, тэнд баахан үглэсний эцэст хоолны ширээнд сууж хүйтэн харцаар ээжийнх нь хөдөлгөөн бүрийг дагуулан харж таваг, халбага, сэрээ, хутгыг сэжиглэн сонжиж, ширхэг дараалан сайтар арчаад дараа нь анхаарлаа төвлөрүүлэн чив чимээгүй хооллоно. Элдвийг үглэдэггүй цорын ганц мөч энэ. Хоол идэж байхад юугаар ч самууруулж болохгүй гэж үзнэ. Тавагтай хоолоо ээжээс нь түрүүлээд идчихвэл “Хоёрдугаар хоол өгөх үү? Өө, өгөх юм уу, баярлалаа” гэж хэгжүүрхэнэ. Ингэж л ярьдаг хүн.

Тэглээ ч гэсэн эцэг! Муу ч бай, сайн ч бай, хүний эцэг, амьдралын чинь нэг хэсэг, Сашагийн одоо ганихарч ээнэгшин дурсаж буй бүхий л юм, тухайлбал хүүхэд ахуй цагийн чинь нэг тасархай. Тэрээр эцгийгээ харгис догшин гэж ер үздэггүй бөгөөд түүний хар амиа хичээх нь л аргагүй хэрцгий. Гагцхүү өөрийн ажил, өөрийн эрүүл мэнд, өөрийн тав тухыг өмнөө барина. Үүнээс болж л одоо ганцаардаж яваа мөртлөө үнэн шалтгааныг нь ойлгохгүй, хүмүүсийн хорон санаанаас болсон гэж үзнэ. Тэгээд түүнээсээ болоод улам ганцаардалд орж байгаа. Саша ялангуяа одоо ганцаардал гэгч юу болохыг биеэрээ амсан таньсан учраас эцгийгээ бүр ч өрөвдөнө.

Наймдугаар сар хуучирч, ахархан намар газардан хөвч тайга шарлаж эхэллээ. Өдөр нь салхи савиргүй дулаахан, шөнөдөө хүйтэн, бараг жавартай гэхээр болж, газар сэврэн хагширч, Сашагийн хачирхсанаар энд тэнд яагаад ч юм бэ улайран, гүехэн уст Мозгова голын хоёр эргээр нарийн мөхөөлдөс үүсэж, замын хонхор хотгороор хөл дор шажигнан байх бүлгээ. Оройн цагаар Ангарын эргээр туулай гүйлдэж, тайгын зүгээс яндан мэт дүнгэнэх дуун сонсогдох нь хандгайн ороо эхэлсэн хэрэг ажээ. Тэгтэл нэгэн долоо хоног өнгөрөх хооронд тайга навч, шилмүүсээ хуу гүвж үхмэл нүцгэн төрхийг оллоо. Нуур цөөрмийн дээгүүр галуу шувууд хоолой мэдэн ганганалдаж, өтгөн олон сүргээрээ гурвалжлан зэллээд өмнийг зорин одож байна. Нарны бараа төдийлөн удахаа байж, үдэш өвөл цагийнх лугаа адил уртсаад ирлээ.

Дараа нь Ангарын ус зайртан, өвөл цагийн чарганы хөдөлгөөн эхэлтэл шуудан хаагдлаа. Орчлон ертөнц, ар гэр, хайрт ээж, Варя бүсгүй энэ тэртэй харилцаж байсан цорын ганц холбоо тасрах нь тэр. Варя нэг ч удаа захиа бичээгүй боловч Саша ээжийнхээ захиа болгоноос түүний амьсгааг мэдэрдэг байлаа. Захиа занаа байхгүй, сонин хэвлэл байхгүй, Варягийн хаягласан хөөрхөн бичиг байхгүй болохоор уйтгар гуниг улам нэмэгдэв. Зида түүнд Кежмагийн номын сангаас хуучин ч гэсэн унших ном олж өгнө. Гэхдээ Макаренкогийн “Сургах ухааны найраглал”, Бруно Ясенскийн “Хүн арьсаа сольж байна”, Гладковын “Эрчим хүч” гэх мэт шинэ ном хаа нэгтээ таарна. Зида тэр номуудыг замын морин тэргэнд дайгдаж явж авчрах боловч ихэнхдээ янган явна. Саша түүнийг юу гэж өөрийгөө зовоож байдаг юм бэ? хэмээн уурлана. Гэвч цаадах нь хүн тусалж өглөө гэх буюу хоёр гуравхан ном, юу нь хүнд байх вэ гээд тоглоом болгоод өнгөрнө.

Саша ном авах гэж тэднийд өдөр очно. Энэ бол хянуур болгоомж байхаа больсных биш. Тэр хоёрын харьцаа урьдын адил нууц хэвээр боловч харин зөвхөн танилын хувиар ил уулзацгаадаг болжээ. Саша жирийн нэг танил шиг өдрийн цагаар тэднийхээр очно, заримдаа Всеволод Сергеевичтэй ханиндаа орж гарна, орой жаахан сууна. Харин хонохоор үлдсэн бол урьдын адил үүр шөнийн заагаар гарч тосгоны ар хударгаар зам буруулж нөгөө талаас нь гэртээ харина.

Зида түүний хөрч хөндийрөөд байгааг мэдэж байсан тул нэг удаа,

–Би чамайг албадаж нөхрөө болгох гэж байна гэж бүү бод. Бодвол чамд Москвад хэн нэгэн бүсгүй бий биз, би бол уйтгар гунигаасаа болоод л зүгээр ингэж байгаа юм. Тэглээ ч гэсэн бийм аз жаргалтай байгаадаа баяртай байна гэж өгүүлжээ.

Тэрээр Зидагийн хацрыг энхрийлэн илсэн боловч түүнтэй ам зөрсөнгүй. Чухамдаа тийм л байгаа юм, харин өөрөө үүнийг ойлгож байгаа нь сайн хэрэг. Москвад хэн нэгэн бий гэдгийг тухайд ч Зидагийн зөв, Москвад Варя нь байгаа, энэ охин түүний зүрхнээс гарахаа больчихоод байгаа билээ.

Саша захиа занаа авахгүй өвлийг яаж хүргэхээ даанч төсөөлөхгүй байв. Гэвч бусад нь болоод л байгаа шүү дээ, өвөл ч бай, зун ч бай, өөрийнхөө байдлыг хүлцэн тэвчиж байгаа, тэгэхлээр мань хүн яагаад тэгж чадахгүй байх билээ? Цөмөөрөө адилхан нэг хувь тавилантай болчихоод, бусад нь оногдсон зовлонгоо эдлээд байхад мань хүн яагаад өөрийнхөө хувийг эдэлж чадахгүй, эдлэхийг хүсэхгүй байх вэ? Бусдын тэвчиж байгаа шиг яагаад тэвчиж чадахгүй байх вэ?

Саша эвлэрэх, тэвчих мэтийн мөхөс байдлын шинжийг илтгэх аливаа ухагдахууныг хэзээнээс нааш харш зүйл хэмээн үздэг байсан учраас эвлэрэхийг хүсэхгүй, тэвчиж чадахгүй байгаа билээ. Түүний хуучин ойлголтоор бол жинхэнэ хүч чадал шал өөр хүмүүст байдаг, мань хүн өөрийгөө тэдэнтэй жишээлэн өргөмжилж, тэдний тоонд өөрийгөө оруулж явжээ. Гэтэл энд бүх юм тэс урвугаар эргэчихээд байна. Мань хүний үл тоомсорлож байсан хүмүүс чухамхүү зовж, тэвчиж чаддаг учраас л өөрөөс нь хүчтэй болж таарлаа. Тэрээр хүчтэний дунд л хүчтэй байжээ. Тэгээд тэр дассан сурсан газраас нь суга татаж, оршин тогтнож байсан орчноос нь салгачихтайгаа зэрэг мань хүн ямар ч тулах тулц байхгүй, гон бие гозон толгойгоороо бол юу ч биш юм байна гэдэг нь тэр даруй мэдэгджээ. Гэтэл энэ хүмүүс бол зөвхөн өөртөө найддаг,

өчүүхэн ч гэсэн байгаа хүчиндээ найддаг, тэр хүч нь ямар ч гай зовлонг үг дуугүй тэвчин өнгөрүүлж, горьдлого найдвараар сэтгэлээ зогоон аж төрөөд байхад хүрэлцээтэй байдаг улс ажээ.

Саша өөрт нь ямар ч аврал энэрэлгүй ийм дүгнэлт хийхэд хүрдэг байв. Хэдий тэгэвч цөхрөнгөө барж эс чадна. Энэ бол түүний туулай шиг зүрхтэйн бас нэг нотолгоо буюу. Тэрээр ийнхүү цөхрөнгөө барж байгаагаасаа өөр юу ч бодохоо больжээ. Тосгоны элдэв сонин, районы боловсролын хэлтсийн замбараагүй байдал, сурлага муутай сурагчид энэ тэр түүнд ямар хамаа байх билээ? Ямар ч падгүй, ямар ч сонирхолгүй дэмий зуйлс...

Гэрийн эзний хуучин үрлэн сумтыг авч, мөн тэдний Жучок хэмээх анч нохойг дагуулан цорхируу авлахаар ой руу өглөө эртлэн гарч, үд дунд эргэж ирээд нар жаргахаас хоёр гурван цагийн өмнө дахиад явна. Энэ хугацаа ан хийхэд сайхан тохиромжтой гэсэндээ ч тэр биш, зүгээр л хараал идсэн нөгөө элдэв бодлыг мартагнаж, биеэ булбартал явах гэсэндээ л тэр. Буу нь хуучин ч гэсэн сум нь зургаан ноймерын яг таарсан сайхан сум. Бас Жучок ч гэсэн чонон төрхтэй сайн нохой. Шувган хоншоортой, харанхуйд улаан цог шиг гялалзсан урт сэртгэр нүдтэй, соотон хоёр чихтэй, лухгар бүдүүн хүзүүтэй, хондлой дээрээ агссан сахлаг сүүлтэй. Бас яггүй ухаантай. Цорхирууг цочирхон үргээхэд хөөрхий шувуу модон дээр нисэж гараад наалдахуйд ялангуяа хагтсан гачуураас бол бараг ялгарахгүй болчихно. Жучок түүн рүү боорлон хуцаж өөр лүүгээ анхаарлыг нь сарниулж байх зуур Саша арав гаруйхан метрээс буудаж, цорхируу үхэтхийн унахуйд Жучок ганцхан ухасхийж очоод зуугаад аваад ирнэ. Саша анд явах бүрийдээ Зидад тав зургаан цорхируу авчирдаг бөгөөд цаадах нь тэдгээрийг цөцгийд шарж, тун амттай хоол хийнэ. Саша тэр хоолыг амтархан иднэ. Ялангуяа Федягаас жаахан спирт олж чадвал бүр салахын аргагүй юм болно. Тэрээр Федяд бас цорхируу өгдөг учраас түүнээс спирт ямар ч байсан олдоно. Федя нэг удаа түүнд,

—Чи цорхируу олныг авлах гэж ойд хол явж байна шүү, тэгж байж баавгайд хүүлүүлчихэв дээ гэж хэлэв.

Саша дал мөрөө хавчин,

—Надтай ер л тааралдахгүй юм байна, баавгай танай нутгийг мартчихсан хэрэг байх аа гэв.

—Санасан нэг нь тааралдах вий гэж Федя жогтой өгүүлжээ. Гэвч Саша түүний үгийг юман чинээ бодсонгүй. Нутгийн ардууд цөллөгийнхнийг анчин гэж огт тоохгүй даапаалах дуртайг алийг тэр гэх вэ.

Саша маргааш нь дахиад ой руу явахаар завдлаа. Гэтэл Жучок өглөө болгон түүнтэй явж амташчихаад хүлээж ядан цовхчиж байдаг атал энэ удаа хашаан дотор ч байдаггүй, гадаа ч байдаггүй. Саша шүгэлдсэн боловч хариуд нь нохой хуцах дуу сонсогдсонгүй. Гэрийн эзэгтэй ферм рүү дагуулаад явсан юм болов уу, эсвэл эзэн нь Кежма руу дагуулаа юм болов уу? Саша нохойгүй явахаар шийдэв. Хуучин шигээ олз ихтэй явахгүй ч гэсэн нүдний цэц тогтсон учраас үргээсэн цорхируу хаашаа нисэхийг харж амжина.

Танил зөргөөр явсаар цорхируу сүрэглэдэг хуучин мэдэх нэг ойн цоорхойд хүрч ирэв... Хэдийн дор зэгэлтэж шарласан хуурай навч шажигнаж, шумалзгана мөчир шад пад хугарна.

Нэг цорхируу дүрхийн нисээд модон дээр суулаа. Тэрүүхэнд нь бас нэг дүрхийх шиг сонсогдсон боловч Саша түрүүчийнхийгээ нүднээс алдчих вий гэж айгаад эргэж харсангүй. Сайхь цорхируу тов тодхон харагдах төдийгүй өөрийг нь сониучирхан, буугаа яаж мөрлөж, яаж шагайж байгааг нь хүртэл ажиглаж байх шиг санагджээ. Саша гохоо дартал яг тэр хоромд өөр нэг буун дуу тасхийж маш ойрхон сум шунгинан өнгөрөв... Саша ухасхийн модны араар орлоо... Саяынх бол үрлэн сум биш ердийн сум, өөр лүү нь буудсан байх нь, нөгөө хоёр дахь цорхируу нислээ гэж санасан чинь хүний хөлийн чимээ байсан болж таарах нь.

Толгойд хоромхон зуур ийм бодол харваж, мань хүн мод руу наалдаад амьсгаа даран ой руу чих тавин зогсов... Ямар ч чимээ анир алга. Буудсан зүг рүү буудах юм уу гэж нэг бодсон боловч бууных нь зөвхөн өрөөсөн гол цэнэгтэй үлдсэн болохоор түүнийгээ буудчихвал гар мухар үлдэнэ гэсэн үг. Буугаа тонгойлгон халаасандаа байсан сумнаас бууныхаа нөгөө голыг болгоомжтой цэнэглэж эхлэв... Гэтэл түүнийг хөдлөнгүүт дахин буун дуу тасхийж сум нь модонд туслаа...

Саша хоёр дахь сумаа бушуухан сумлаж гохоо сойж, дахин хүлээзнэн нам гүм болов. Тэгтэл юм шажигнан, мөчир шад пад хугарах чимээ сонсогдсоноо хөлийн чимээ гарч нөгөө буудсан этгээд зугтаж байгаа нь мэдэгдэв... Тэгээд нам гүм болов.

Саша хоргодсон газраасаа гарч зүрхлэхгүй нэг хэсэг чимээ чагнан хүлээзнэв. Дараа нь нөгөө буудсан хүний зайлж одсон зүгийн эсрэг тал руу зам жим гэлгүй ой дотуур, намхан нэвсийсэн мөчир дундуур шурган гэтсээр Ангара руу гарч ирэв. Гэвч голын эрэг рүү буулгийн ойн захыг бараадан явсаар тосгонд хүрлээ.

Хэн буудав аа? Санамсаргүй нэгэн тэнэмэл буугий нь авах гэж тэгэв үү? Ээ, үгүй байлгүй дээ. Буудсан болохоор тэр хүн өөрөө буутай байсан байна. Энэ тосгоныхны л нэг нь буудсан байх, Тимофей буудаж л дээ, яг тэр нөхөр! Федягийн анхааруулаад байсан чинь учиртай юм байна, ийм баавгайн тухай ярьж байсан байх нь. Сашагаас хариугаа авна гэж Тимофей онгирч байсан хэрэг. Энд чинь өсөө авахаа хүрвэл сууринд отоож байгаад л баавгайд зориулдаг том тугалгаа ч хамаагүй зоочихно. Уул нь Федя, Тимофей чамайг ална гэж зангаад байна гээд хэлчихвэл болох л байсан шүү дээ. Гэтэл Тимофейн зангаад байгааг мэдмэгц Саша захиргаанд мэдэгдэж Федяг өөрийг нь гэрч болгочихно гэж болгоомжлон юманд орооцолдохгүй гээд хэлсэнгүй. Тимофей Сашаг алчихсан байлаа гэхэд хэн ч хэл ам гаргахгүй байсан. Саша тэд нарт юу юм бэ? Өнөөдөр байж л байна, маргааш мөрөө хөөгөөд л алга болно, гэтэл Тимофейтэй, тэднийхэнтэй эндхийн улс нэг дороо аж төрцгөөх ёстой. Тэгэхлээр Федя ч гэсэн хэл ам гаргахгүй л байсан. Ер нь энэ хэргийг хэн ч сөхөж хөөцөлдөхгүй, үхсэн гээд л данснаас хасчихна, энэ газрын мухарт хэрэг мөрдөж байх дуртай хэн байх вэ дээ.

Гэртээ ирж орон дээрээ сунайн унасны дараа л чухамхүү ямар аюулын ирмэг дээр байснаа Саша сая ухаарав. Эцэс төгсгөлгүй мэт санагдах амьдрал чинь ганцхан хоромд тас үсэрч мэдэх эд байна. Суманд өртөж болно, завь хөмөрчихөж мэднэ, цөллөгийн замд туйлдаж болно, санаандгүй өвчин тусаж мэднэ, тэглээ гэхэд хэн ч түүнд тус нэмэр болохгүй, түүнийг үхлээ гэж хэн ч харамсаж гутрахгүй, ер нь тэрээр хэнд ч хэрэг алга, хэн ч түүнийг өмөөрч хамгаалахгүй, гомдол мэдүүлэх ч хүн алга! Алфёровг мэдүүлэх үү? Гэтэл нөгөөдөх чинь чухам яагаад Тимофейг хардаж байна вэ? гэж асууна. Өө, нэг удаа түүнийг зодчихсон юм уу? Орон нутгийн хүн амтай сөргөлдөж харгалдахын хэрэг байхгүй, тэд нар чинь бас л тантай

адилхан хүмүүс, өөрийн гэсэн нэр төртэй, өөрийн гэсэн зан араншинтай улс, үүнийг бодолцох хэрэгтэй. Түүнээс гадна та энэ нутаг заагдсан газраасаа тийм хол явах эрхтэй билүү? гэж асууна. Галт буу ашиглах эрхтэй билүү? За ингээд гүүний гомдлын мөрөөр ямар ч үр дагавар гарахгүй болохоор өөрөө улам ивээл өмгөөлөлгүй болж, харин дайснууд нь өөрсдийгөө ял зэмгүй улс гэж улам оодорно.

Хүнд хэлснээр ямар ч ашиг гарахгүй. Тэрээр өөрөө л өөрийгөө хамгаалах ёстой. Харин яаж хамгаалах вэ? Ойд явахаа болих уу? Тимофей Ангарын хөвөөнд отож байгаад юм уу, эсвэл зүгээр гэртээ байхад нь цонхоор нь буудаад алчихсан ч чадна. Ер нь хэзээ араас буудчих бол гэж байнга айж эмээж яаж аж төрөх вэ? Юмны хамсаанд бас нэг ийм юм байх гэж! Яасан учир начиргүй хорвоо вэ! Өөрөө л хэргийн эзэн! Яах гэж Тимофейтэй ойртсон юм бэ? Яах гэж түүнтэй хадланд явсан юм бэ? Тэд нараас аль болохоор хөндий байх ёстой байхад өөрөө нялуурч нэг зиндааны хүн шиг царай гаргаж байгаад Тимофейгээс ивээл ирж, түүнээс айж байгаа юм шиг түүнд ойлгогдож тэр этгээд даапаалж доромжилж болно гэж санажээ! Тэгээд түүнийг нь эсэргүүцэж няцаасныг үл тэвчин өшөөгөө авахаар шийдсэн байна. Ихэмсэг дээрэлхүү байхын хэрэггүй, гэхдээ бас хүмүүсийг зулгуйдаж царайчлах нь зохисгүй, хүн янз янз шүү дээ.

Саша орой нь Федягийн мухлагт очиж хүмүүс гарч дуусахыг хүлээж байгаад,

–Чиний зөв байна шүү, танай ой чинь баавгайтай юм байна гэж хэлэв.

Федя хараа буруулан,

–Өө тийм үү... гэв.

Асууж шалгаах ч үгүй, ямар баавгайн тухай ярьж байгааг ойлгож байгаа вий.

Саша мухлагаас гарч Тимофейн байшингийн дэргэдүүр өнгөрөхдөө алхаагаа саав. Ороод гардаг юм билүү? Тэр муу өлөгчний хүүг харах минь! Үгүй ээ, хэрэггүй, биеэ барих хэрэгтэй, болчимгүй загнаж хэрхэвч таарахгүй.

Энэ явдлын тухай Саша зөвхөн Всеволод Сергеевичид ярьж, Зидад нэг ч үг цухуйлгаж болохгүй гэж захив. Всеволод Сергеевич хөмсөг зангидан духаа үрчийлгэв.

–Энэ ч таны бодож байгаагаас илүү ноцтой доо.

–Би цөмий нь сайн ойлгож байна. Тэр намайг алчихаад ямар ч ял зэмгүй өнгөрнө гэдгийг ч ойлгож байна.

–Сэрэмжтэй байж үзээрэй хэмээн Всеволод Сергеевич зөвлөөд –Ганцаараа ойд битгий явж бай, хүсвэл хоёулаа ханиндаа явж байя л даа гэв.

–За яахав, байдлыг харъя гэж Саша дүйвүүлсхийн өчив.

Гэртээ ирээд Жучок өглөө хаа байсныг гэрийн эздээс асуув. Гэтэл хэн нь ч нохойгоо дагуулж явуулаагүй байх ажээ.

–Таныг дагаад ой руу явчихсан юм байх л гэж бодсон гэж эзэгтэй хариулжээ.

Тимофейн хийж байгаа ажил гэдэг нь тодорхой, тэр муу чонон дотор л Жучокийг нэг газар нуучихсан хэрэг.

Жучок довжоон дээр хэвтчихсэн, өөрийнх нь тухай ярьж байгааг мэдээд Саша эзэгтэй хоёр руу ээлжлэн харж байв. Саша түүний хошууг илбэж,

–Маргааш хоёулаа баавгайчилна, Жучок минь, бэлтгээрэй гэв.

Тэрээр гэрийн эзний пингээс жижгэвтэр гулуузан хар тугалга олж баахан сум зоров. Тэгээд бууныхаа нэг голыг үрлэн сумаар, нөгөөг нь тугалгаар цэнэглэв. Тимофей ойртох гээд үзэг.

Гэвч Саша ойд явах хэрэгцээ гарсангүй.

Түүнийг орноосоо босоогүй өглөө эрт байхад тосгоны зөвлөлөөс нэг хүн ирж зурвас гардуулжээ.

“Зах. цөллөгдөгч А. П. Панкратовт. Үүнийг авмагц ДЯАКХ-ын Кежмагийн районы бүрэн эрхт төлөөлөгч В. Г. Алфёров дээр Кежма тосгонд ирж уулзахыг мэдэгдэж байна” гээд Алфёровын хэдийн танил болсон гаргацтай гарын үсэг байв.

Лёвочка Варяг үйлдвэрчний эвлэлд элсэх цаг чинь болсон гэж түүнд хэлжээ. Хоосон ёс төдий ч гэсэн хэрэгтэй зүйл. Варя өргөдөл өгөв.

Гэтэл хоосон ёс төдий зүйл биш ажээ. Үйлдвэрчний эвлэлийн бүх гишүүдийн хурлаар элсүүлж, нөгөө л маягтад байдгийн ижил асуултууд тавьцгаалаа. Варя дотроо бухимдан, “нөхөртэй эсэх” гэсэн асуултад “нөхөртэй” гэж хариулмаар санагдсан боловч маягтад өөрөөр хариулсан учир элдэв юм лавшруулан шалгааж бүр доромжлолын бай болно гэж бодоод “үгүй, нөхөргүй” гэж хэлэхэд Зоя болон бусад хэдэн охины царайд гайхах янз мэдэгдсэн боловч тэд нар тодруулж асуусангүй. Төвийн Гүйцэтгэх Хороо, ЗСБНХУ-ын Ардын Комиссарын Зөвлөл, ЗСБНХОУ-ын Ардын Комиссарын Зөвлөлийн дарга нар хэн хэн бэ, социалист нийгмийг байгуулах, социалист нийгмийн суурийг байгуулах хоёр ямар ялгаатай, чухам аль нь манайд байгуулагдсан бэ гэхчлэн улс төрийн асуудлууд тавив. Өдөр болгон уулздаг, сайхан нөхөрлөж байгаа сайн танил хүмүүс нь нэг л их мундаг төрийн хэрэг явуулж байгаа юм шиг, Варягийн худлаа хэлснийг уудлан илрүүлэхээс буцахгүй гэнэтхэн хачин хардаж сэрдсэн байдалтай болчихсоныг үзээд Варя гайхахын ихээр гайхжээ. Тэр ч байтугай Рина, Лёвочка хоёр, түүгээр ч барахгүй Игорь Владимирович хүртэл дүрэмдсэн царайтай болжээ. Маягтаар нь хамаг юмыг нь шалгачихсан, ямар ч маапаангүй юм чинь тэртэй тэргүй л элсүүлээд авах байтлаа ингэж байх нь үнэхээр мунхаг гэлтэй. Ямар нэг ёс ёсолж, хэнд ч улиг домог болчихсон ажил явуулж байгаа, асуудлыг хэлэлцэж байгаа дүрнээс цаашгүй.

Асуулт дууслаа. Игорь Владимирович босож, Иванова өөрийнх нь хэсэгт ажилладаг, ажил үүрэгтээ үнэнч, үйлдвэрчний эвлэлийн гишүүн байж бүрэн болох хүн гэж хэлэв. Игорь Владимировичийн энэ албархаг яриаг сонсоод Варягийн нүд нь орой дээрээ гарчээ.

Бүгд нэгэн дуугаар “авья” гэж санал өгцгөөлөө. Үүгээр бүх юм дуусах нь тэр.

Тэгээд хүмүүс суудлаасаа босонгуут олон нийтийн үүргээ биелүүлэв гэсэн шиг царай нь өөрчлөгдөн нөгөө албархаг төрх нь ая тал зассан янзаар солигдож Варяд баяр хүргэцгээн гэрийн зүг яаравчлав.

Игорь Владимирович хоёрдугаар давхарт ресторанд орж Варягийн үйлдвэрчний эвлэлд элссэнийг тэмдэглэх санал тавив. Рина “Гранд-отельд” ороход хувцас гологдоно, амрыг ч бодсон, түргэн үйлчлэхийг ч бодсон “Канатикт” очъё гэв. Лёвочка түүнийг дэмжлээ. Игорь Владимирович мөнгийг нь даах учраас түүнээс их зардал гаргуулах нь эвгүй гэж бодсондоо тэгсэн юм байж. Варя хаашаа ч явмааргүй байв. Рина, Лёвочка хоёр өчүүхэн амьтад яая гэхэв, ажилгүй болгочихно гэж айдаг байя гэж саная. Гэтэл Игорь Владимирович юу ч вэ дээ! Ямар нэг юмаар бусдаас ялгарч даанч болсонгүй гэж үү? Алдар цуутай уран барилгачин хүн юм чинь түүнд айх юм юу байх юм бэ? Ярьж байгаа юм нь улиг домог, ёсолж байгаа ёс нь утга учиргүй гэдгийг ойлгож байгаа хэрнээ яг л нөгөө албархаг үгээр ярьж байх юм. Ингэж санахаас Саша Панкратов иймэрхүү хурал цуглааныг чухал гэж үздэг байж болох авч ямар ч атугай байдгаараа л байх байсан гэж Варяд гэнэтхэн бодогдов. Саша бол шууд босоод л бүх юм намтарт нь бичээтэй байхад элдэв юм асууж цаг урж байхын хэрэг юу байна гэж хэлнэ. Мань эр бол өөрийн гэх нүүр царайтай хүн учраас мэдээж тэгж хэлнэ, харин Игорь

Владимирович бол тийм хүн биш!.. Ийм учраас Варяд хаашаа ч явах хүсэл байсангүй, гэвч өөрт нь зориулсан найрархуу юм болох гэж байхад дургүйцэх эвгүй юм даа.

Рождественка, Театрын зөрөг хоёрын уулзвар дээр анхны ном хэвлэгч Иван Фёдоровын хөшөөний эсрэг талд байдаг хоёрдугаар зэргийн рестораныг “Канатик” (“Олст”) гэдэг билээ. Байшингийн газар давхарт байрладаг энэ рестораны хана нэлдээ нарийвтар олсоор чимээстэй байх учир тийнхүү нэршсэн ажээ. Варя “Канатикт” ерөөсөө орж үзээгүй. Энд бильярд байхгүй учраас Костя ийшээ ирдэггүй юм. Харин нэг удаа Вика ийшээ цуг явъя гэж уриалсан боловч Варя тэр үед Лёвочкагийн бүлэгтэй байсан нь дээр гэж санаад яваагүй. Тэгэхэд бас Игорь Владимировичтэй цуг явах байсан билээ. Гэтэл одоо ингээд түүний хамт “Канатикт” ирчихдэг байна.

Түүний танилуудаас нэг ч хүн тэнд байсангүй. Баасан гаригт “шарсан тахиан” дээр бүх хүн цугладаг юм гэж Рина хэлэв. Тэрээр бүх хүн гэж ресторанаас салдаггүй амьтдыг хэлсэн ажээ.

Игорь Владимирович рестораны намхан пөмбөгөр адрыг эргүүлдэн харах зуур,

–Тэгсэн ч гэсэн овоо хүнтэй байна гэж өгүүлэв.

–Хотын төвийг ч хэлэх үү, бас ажил тарсан болохоор хүн элбэг байх нь хэр гэж Лёвочка тайлбарлав.

–Албан хаагчдын ажил дуусаж, завхай эмсийнх эхэлж байна гэж Рина Игорь Владимировичээс санаа зовохгүй хэлэв. Одоо бол дарга биш цуг наргиж яваа хүн гэж буй хэрэг.

Хүмүүс орж гарсаар байх бөгөөд гурван бүсгүй орж ирж тэдний ширээнээс холгүйхэн сууцгаав. Рина, Лёвочка хоёр хоромхон зуурын төдийд бие бие рүүгээ сэрдхийн харах шиг болсныг Варя анзаарч, гагцхүү түүнээс болоод тэр гурав дээр хараа тусжээ.

Тэр гурав бол Ринагийн хэлдэг ажил нь дөнгөж одоо эхэлж буй рестораны нөгөө шалиг хүүхнүүд ажээ. Ажлаа эхлэхийн өмнө ресторанд харчуулгүй ийнхүү сууж, өөрснийгөө мөнгөөр амны заваа гаргаж, эмсийн элдэв явдлыг харилцан бурж, хоол зөөгчийн шанд өөрснөө хэдэн мөнгө чулуудаж, ердийн хүүхнүүд шиг царайлна гэдэг бол тэдний хувьд хамгийн том баяр.

Нэг бүсгүй нь цаашаа харж сууж таарчээ. Нөгөөдөх нь түүнд нэг юм шивэгнэсэнд тэрээр Варягийн ширээ рүү эргэж хараад Рина, Лёвочка хоёр руу хээвнэг дохив. Мань хоёр хариуд нь мөн толгой дохиж, баяртай мишээж буй дүр гаргав. Гэвч нөгөө хүүхэн тэр хоёрыг бус Варяг тогтож харснаа тоомсоргүй инээхчээ аядаад цаадуул руугаа эргэж нэг юм хэлэхэд цөмөөрөө ЧАНГА инээд алдацгаав. Сайхь хүүхэн хамартаа ойрхон нүдтэй, шар үстэй, бодвол хорин тав эргэм настай, цагтаа царайлаг байсан болов уу гэмээр цонхигор нүүртэй, гойд сүржин дэгжин биш боловч аятайхан хувцасласан туранхай нэгэн аж.

Лёвочка, Рина хоёр дахин бие бие рүүгээ санаа зовсон янзтай харахыг Варя анзаарч, бас нөгөө эм өөрийг нь дэндүү доогтой, тэр ч байтугай тавлаж шоолсон мэт цоргин харсныг

бодохоос өөрөө ч хачин оргиод явчихав.

–Юун хатагтай билээ? гэж Варя асуув.

–Нэг газар тааралдсан л юм байна, чухам хааныг санахгүй байна гэж Рина тоомсоргүй маягтай хариулсан боловч тэр тоомсоргүй янз нь зохиомол зүйл гэдэг нь илт байв. Тэр эм бас Лёвочкаг мэдэж байна, тэгэхлээр хаа нэг газар тааралдаж байсан нь санамсаргүй хэрэг биш гэсэн үг.

Игорь Владимирович бас аягүйцсэн бололтой, энд удаан суух цаг байхгүй гэдгээ ойлгуулан цагаа харснаа хундгаа өргөв.

–Варя, танд баяр хүргэе. Та одоо бүрэн эрхт хөдөлмөрчин болсон, амжилт хүсье.

Цөмөөрөө ууцгаалаа.

Шар толгойтын хэлсэн бас нэг юманд нөгөө гурав дахиад чанга инээд алдацгаав.

Игорь Владимирович дахиад цагаа харлаа. Рина бас явахыг завдах зуур,

–Та яарч байна уу? гэж асуув.

–Тийм, ер нь ч болсон байлгүй...

–Нээрэн тийм хэмээн Лёвочка тосгуулан дэмжив. Шар толгойт эргэж харлаа.

–Лёвушка!

Лёвочка тэдний ширээ руу очиж шар толгойт руу тонгойн тэр хоёр юм ярилцав. Лёвочка ялдамхан инээмсэглэн, шар толгойтын мөрийг энхрийлэн илбэж байснаа буцаж ирэв. Шар толгойт бас нэг инээдэмтэй юм хэлсэн бололтой нөгөө ширээнийхэн дахиад тачигнатал инээд алдацгаав.

Лёвочка эргэж ирээд Москвад айлчлан тоглох гэж байгаа Скоморовскийн жааз хөгжмийн хамтлагийн тухай аанай л ялдамхан янзаараа ярьж эхлэв. Рина түүний энэ дүйвүүлсэн яриаг чих тавин чагнаж байвч сэтгэл түгшиж буйг нь Варя мэдээд байлаа.

Шар толгойт босоноо тэдний ширээ руу ирж Варя, Игорь Владимирович хоёрыг зэрвэсхэн ширэв татав. Тэрээр папирос барьжээ.

–Шүдэнз олдохгүй биз?

Шижээргүй нүүрэмгий зангаа зориуд барьж, цаагуураа өдөх санаатай байгаа нь түүний хөдөлгөөн бүрээс мэдэгдэж байв. Игорь Владимирович хайрцагтай шүдэнзээ өгөв. Хүүхэн шүдэнз зурж тамхиа асааснаа гэнэтхэн Варя руу эргэж,

–Костятай аж төрөхөд ямар байна? гэв.

–Клава, Клава хэмээн Лёвочка түүний тохой руу нудрав.

–Болохгүй юм юу байна? Би сонирхож байна. Энэ чинь шинэ авгай нь, би бол хуучин нь. Би хоёр зуу дахь нь, энэ хоёр зуун нэгдэх нь. За, тэгээд яажшуухан аж төрж байна? Чамд одоохондоо юугаар ч шан хайрлаагүй байна уу?

Варя эхлээд асуултыг ойлгосонгүй, жирэмслэх тухай битүү хэлж байна гэж боджээ.

–Клава, болиоч! гэж Рина шируун хэлэв.

–За! Чи муу, дуугаа тат! гэж шар толгойт хэрцгийлэв.

Варя түүний хэлсний учрыг ойлгомогц,

–Янхан хүүхэн гуай, аль вэ, эндээс тонил! гэж тайван бөгөөд тов тод хэлэв.

Хэрүүл маргаан дэгдэх нь хэмээн цөмөөрөө балмагдан хэлээ залгисан мэт болцгоов.

Игорь Владимирович санаанд оромгүй чанга дуугаар,

–Манай ширээнээс холд. Битгий хоргоогоод бай! Ойрд сэргийлэхэд хоноогүй юм уу? Шуурхай зохион байгуулаад өгч болно шүү гэж чарлав.

–Үгүй ер, мөн айлгав аа... хэмээн шар толгойт муухай тас тас хөхрөв.

Хоёр найз нь бушуухан босож ирээд түүнийг ширээ рүүгээ аваачих гэж хэдийн чангаацгааж байна. Цаадах нь тулхэлцэн цааргалж,

–Би түүнийг хүн шиг бодоод харьцаж байхад мууг минь дуудна гэнэ ээ, өөдгүй новш! Сургууль төгсөөгүй байж гудамжинд гарчихсан хэрнээ намайг муулж гэнэ! хэмээн хашгичив.

Игорь Владимирович зөөгчийг дуудаж мөнгөө төлөв.

–Өөрөө түүний эхнэр, түүнийг өөрийнхөө нөхөр гэж бодож явдаг байх нь. Түүнд чам шиг эхнэр бүтэн вагон илүү бий, цөмөөрөө хүйтэндчихсэн байхыг нь яана... Ринагаас асууг л даа, бас тийм хишиг түүнээс хүртэж явсан хүн, одоо болохоор тэр мууд залуухан охин дэвсээд өгсөн байна, муусайн банзлууд! гэж шар толгойт агсрав.

Ресторанаас эрхбиш гарцгаалаа. Лёвочкагийн гэр Сретенкад учраас тэрээр,

–Би зүүн тийшээ явна гэж өгүүлээд,

–За, тоохын хэрэг огт байхгүй, солиотой эм юм чинь, за баяртай! гэв.

Варя, Рина, Игорь Владимирович гурав доошоо уруудан Театрын талбай руу явцгаав.

–Ямар бузар амьтан бэ! Юу гэж донгосов оо! Юу зохиогоод чалчихав аа! хэмээн Рина

бухимдав.

–Ийм газраар орж байхын хэрэггүй юм гэж Игорь Владимирович өгүүлэв.

–Энэ солиоттой бид хаа ч тааралдаж мэдэх байсан юм.

Игорь Владимирович Варяд хандан,

–Битгий гутар, амьдралын аар саар юм шүү дээ, тоож юм бодохын хэрэггүй гэж хэлэв.

–Надад гутарсан юм алга гэж Варя баргар өгүүлэв.

Тэрээр гэртээ ирэв. Цаг үдшийн арав болчихсон тул ажил хийхэд нэгэнт оройтож, унтах тийшээ хандсан нь дээр болжээ. Гэвч “Канатикт” тохиолдсон явдлаас болж чих дөжирч, дотор балартам балмагдсан учир цаг эрт байлаа ч гэсэн тэртэй тэргүй ажиллаж чадахгүй байхсан билээ. Рина, Лёвочка хоёрт хэргийн учир байгаа биш, тэд нар бол Костягийн найзууд, гэхдээ Рина зүгээр нэг найз ч биш түүний “дансны” хүн бололтой. Костягийн ханш тэр л дээ. Өөрийнх нь гэрлэлтийн тухай тиймэрхүү үнэн Игорь Владимировичийн хувьд санаанд оромгүй зүйл болсон нь мэдээж. Гэтэл Игорь Владимировичийн хурал дээр байсан янз, бас тэр ресторанд айснаасаа болж чарласан энэ тэр нь Варягийн хувьд мөн санаанд оромгүй зүйл байсан юм. Хэрвээ над руу зодоончид дайрвал тэр энэ чарлаа дуугаараа тусламж гуйн хашгирах байсан биз ээ. Номхон төдийгүй бас аймхай нөхөр. Саша бол түүнийг арай өөр аргаар өмөөрөх байсан даа. Тийм учраас Игорь Владимировичтэй өгөө аваагүй болох нь тэр. Рестораны завхай хүүхэн өөртэй нь эн тэнцүүхэн юм шиг ярилцаж, тэр нь урьд өмнө Костягийн зайдан хүүхэн байсан, одоо өөрөө түүний тийм хүүхэн нь болчихоод байна гэж бодохоос Варя өөрөө өөрөөсөө ичиж гүйцлээ. Тэрээр хэзээ ч ингэж доромжлуулж яваагүй билээ. Маргааш яаж ажилдаа явж, яаж хүн амьтны нүүр харна даа.

Яадаг юм билээ, яаж энэ бүхнээс ангижрах вэ, тэнгэр минь! Зоргонд нь хаячихаад Нина руу эргэж очдог юм билүү, гэвч хөөрхий Софья Александровнаг хөөдөх ёсгүй, тийм эрх ч байхгүй. Нэр нүүрээ барсан Костя Софья Александровнагийн амьдралыг нэгмөсөн үрэн таран хийчихнэ. Балмад этгээдийг гэрт нь авчирчихаад өөрөө зугтчихна гэж яаж байх вэ, тэгэх юм бол хэзээ ч өөрийгөө өршөөхгүй нүгэл болно. Түүнтэй зад хэрэлддэг юм уу? Байранд баахан шуугиан дэгдэж, Софья Александровнад нэмж гай тарихаас өөр үр дүн гарахгүй.

Хаалга тогшлоо.

–Ороорой.

Тэр нь Софья Александровна байв.

–Варя, сайн байна уу?

–Сайн, сайн байна уу, Софья Александровна, та суугаач, ажил явдал ямар байна?

Софья Александровна суугаад Варяг анхааралтай ширтэв.

–Ямар нэг санаа зовох юм гараа юу?

–Зүгээр л ядраад энэ, хурал болж үйлдвэрчний эвлэлд элсүүлээд.

–Ёс төдий алба, гэхдээ хэзээ ч юм бэ, дайрах шаардлагатай алба.

Софья Александровна Варя руу дахиад харав.

–Варенька, би нэг ийм юм ярих гэсэн юм... Өнөөдөр Константин Фёдорович нэг хүнтэй хамт хүрч ирээд хаалгаа ч гүйцэд хаачихгүй буу задлан оролдож, замгийг нь тачигнуулаад байна лээ. Бид нар чинь хэлэлцэж тохиролцсон шүү дээ. Варенька, яаж ингэж болох юм бэ?

Варя шүүгээгээ онгойлгов. Хувцасны цаана ангийн хоёр буу түшүүлээд тавьчихсан байв.

Тэрээр орон дээрээ сандайлан суухад хоёр гар нь хар аяндаа сульдан алдрав.

–Софья Александровна, би таны өмнө түмэн буруутай. Би түүнийг танай гэрт дагуулж ирэх эрхгүй байсан юм.

–Гэхдээ чи чинь түүний эхнэр шүү дээ.

–Эхнэр... Бид хоёр ямар юмных нь эхнэр нөхөр байх вэ дээ! Яагаад ийм хэрэгт ороолдчихсоноо би ойлгохгүй юм. Тэр бид хоёрын хооронд ямар ч хамтын амьдрал алга, би түүний барааг бараг харахаа больсон, бид хоёр аль хэзээний эхнэр нөхөр биш болжээ.

Софья Александровна дуугарсангүй.

–Гэтэл би юу ч хийж чадахгүй, хавханд орчихоод байна гэж Варя цөхрөн өгүүлэв.

–Хавханд ий? хэмээн Софья Александровна гайхширч,

–Юун хавх вэ? Би чамайг ойлгохгүй байна. Та хоёрт гэрлэлтийн баталгаа байхгүй юм чинь чи эрх чөлөөтэй хүн, бас амь зуулгаа өөрөө болгоод байна гэв.

–Тэр нь ч тийм л дээ. Гэхдээ би эндээс явж чадахгүй байна.

–Яагаад?

–Яахав, намайг явчихвал цаадах чинь танайхаас салахгүй. Өөрөө ч яг тэгж хэлсэн. Чи явбал яв, надад энд ч сайхан байна гэсэн. Өөрөө өөр байр олно гэж хэлэх нь хэлсэн, гэхдээ худлаа ярьж байгаа л даа, тэр чинь байр заяа нь хайхгүй. Тэгэхлээр би түүнийг энд орхиж болохгүй, та түүнийг яаж ч чадахгүй. Харахгүй юу, намайг байхад хүртэл энэ буунууд авчирчихаад байгаа юм чинь байхгүй бол бүр эрээ цээрээ алдаж гүйцнэ, таныг өрөөндөө ч оруулахаа байчихна.

Софья Александровна түүний толгойг илбэн инээмсэглэв. Тэгэхүйд ээж нь яг Саша шиг инээмсэглэж буйг Варя гэнэтхэн олж харлаа. Саша яг ингэж инээмсэглэдэг юм. Бас тэдний

нүд нь ч адилхан юм байна.

–Варенька, чи минь миний төлөө санаа зовоод яасан сайхан сэтгэлтэй юм бэ дээ. Миний төлөө санаа зовохын хэрэг байхгүй хэмээн Софья Александровна эелдэгхэн өгүүлээд,

–Чи үнэхээр л салахаар шийдсэн юм бол... гэв.

–Үгүй ээ, бид хоёр аль дивангарт салчихсан юм!

–Охин минь, аль муудалцахыг тэр гэх вээ, тэгсний төлөө залуу хүмүүс дэндүү түргэн зан гаргаж салцгаачихаад хожим буцаад нийлцгээдэг юм.

–Муудалцах... хэмээн Варягийн хоолой чичирч,

–Тэр чинь миний юмнуудыг мөрийд алдаж байна. Нөгөө нөмрөгийг санаж байна уу? Би тэгэхэд танд худлаа хэлсэн юм, түүнийг чинь мань хүн бильярдын мөрийд алдчихсан байна лээ. Хэрэгцээ гарвал намайг ч гэсэн мөрийд алдчихаж чадах хүн. Түүний бүх ажил сэжигтэй, нөгөө дэнлүү, цахилгаан тоноглол энэ тэр гээд байгаа чинь цөм хуурамч зүйл, түүний эд хөрөнгийг бүртгээд битүүмжилчихсэн, би ийшээ бас ирж бүртгэх байх гэж айж байсан юм, ашгүй аз болоход ирсэнгүй, түүний завхай охид намайг доромжилж байна. Би түүнийг харахаас дургүй хүрч байхад та муудалцахын тухай ярьж байх юм... гээд уйлчихав.

Софья Александровна түүний толгойг дахин илэв.

–Охин минь, тайвшир, яаж ингэж цөхөрч болох юм бэ, чи надад итгэ, сүйд болсон юм ер алга! Чи яагаад энэ бүхнээ надад эртхэн хэлсэнгүй вэ?

–Би ичээд байсан юм гэж Варя нулимсаа татах зуур өчив.

–Ичиж байх ямар хэрэг байна, тэнэгхэн ч толгой бол доо, би чинь туршлагатай хөгшин авгай шүү дээ, чи бид хоёр аргыг нь түргэн олчих байсан юм, аль хэзээний олчих байсан. Чи гэртээ харимаар байна уу, эсвэл манайд баймаар байна уу, хэлчих?

–Уул нь би танайд л баймаар байна л даа. Гэвч тэгэхийн арга алга, Софья Александровна минь, арга байхгүй. Би эндээ үлдвэл цаадах чинь зайлж өгөхөө үзэхгүй, зайллаа гэхэд утасдаж хэрүүл шуугиан тариад таныг шар махтай чинь хатаачихна. Түүнийг танаас салгах л надад чухал байна.

–Бүү санаа зов, би өөрөө түүнээс чинь хагацаж дөнгөнө. Чи л хатуу шийдсэн юм бол... гэж Софья Александровна уужуухан өгүүлэв.

–Софья Александровна!

–За зүгээр, зүгээр... Тэгвэл одоо юмаа эмхлээд Нина руу буцаж оч. Бусдыг нь би өөрөө янзалъя.

Түүний эрсхэн бөгөөд уужуухан занд Варя бүр гайхаж хоцров. Саша яг л ийм шүү дээ. Ээ

халаг минь, энэ авгайг ерөөсөө мэддэггүй явжээ, гагцхүү зовлонд нэрвэгдсэн эх хүн байна гэж өдий хүртэл бодсоор яваад Софья Александровнагийн жинхэнэ зан чанарыг олж хараагүй юм байна.

–Түүний худалдаж авч өгсөн юмнаас би юу ч авахгүй.

–Өөрөө л мэдэх хэрэг, харин бушуулж үз, эс тэгвэл цаадах чинь хүрээд ирж мэднэ.

Костя хэзээ ч ийм эрт ирдэггүй билээ. Гэвч Лёвочка, Рина хоёрын нэг нь “Канатикт” болсон хэрүүлийн тухай түүнд заавал хэлэх учраас тэрээр хэзээ хэзээгүй хүрээд ирж мэднэ гэдгийг Варя ойлгож байв. Тэрээр юмаа чемоданд хийх зуур,

–Бүгдийг нь нэг амиар аваачиж чадахгүй юм байна, бас зургийн самбар, чиг хоёроо авах хэрэгтэй. Зарим юмаа таны өрөөнд орхичихоод дараа эргэж ирээд авья тэгэх үү? гэв.

–Асуухын хэрэг юу байна?

Варя пальтогоо өмсөөд нэг гартаа чемодан, нөгөө гартаа зургийн самбар, чиг хоёроо авав.

–Арын хаалгаар гарчих, гэнэтхэн нөгөөдөх чинь тааралдчихаж магад.

–Тэр муу яахав! Би зөвхөн таныг яах бол л гэж айж байгаа юм.

–Миний төлөө санаа бүү зов гэж би чамд хэлсэн шүү дээ, гэхдээ чи ямар ч атугай арын хаалгаар гар, шатан дээр хэрүүл хийх хэрэггүй юм гэж Софья Александровна нухацтай хэлэв.

–За тэгье.

Варя Софья Александровнаг үнсэв.

–Танд их баярлалаа, намайг уучлаарай.

–Хүү минь, чамайг яасан гэж уучлах билээ дээ, харин намайг хаяхгүй байгаад чинь чамд л баярлалаа. Юмны учир олдож зохицмогц эргээд ирээрэй, би баярлана шүү.

Варя байрныхаа хаалгыг онгойлгоход өрөө нь түгжээгүй, Нина ширээнийхээ ард дэвтэр засаад сууж байв.

Зургийн самбар, чемодан энэ тэр барьчихаад пальтотой зогсож буй Варяг хармагц,

–Гэр бүлийн аз жаргал дуусаа юу? гэж асуув. Варя чемоданаа шалан дээр орхиж, самбараа орон дээр тавиад,

–Дууссан гэж өчив.

Варя Костяг эрт ирчихээд утасдаж гарна гэж санаад бухимдаж байв. Тэгтэл утасдсангүй. Бахь байдгаараа оройтсон гэсэн үг.

Маргааш нь ажил тарахаас хоёр цагийн өмнө Игорь Владимирович Лёвочкаг утсаар ярья гэж байна гэж өрөөнөөсөө дуудав. Ийм дуудлага ер бусын зүйл билээ.

Лёвочка хэдэн минутын дараа эргэж ирээд Варяд түүнийг утсан дээр дуудаж байна гэж хэлэв.

–Костя юу?

–Тийм.

–Энэ утсыг яаж мэддэг юм бэ? Хариулахын оронд Лёвочка дал мөрөө хавчив.

–Игорь Владимировичийн утсаар ярих ёс манайд байхгүй. Нийтийн утас бий, ноймерыг нь Костя мэднэ шүү дээ.

Лёвочка дахиад дал мөрөө хавчив.

–Яаралтай, маш түргэн гээд байна лээ. Би Игорь Владимировичээс чамайг дуудаж болох уу гэж асуухад болно гэж хэлсэн юм.

–Очоод нийтийн утсаар утасд гээд хэлчих.

–Чи өөрөө очоод л хэлэхгүй юу, би ямар дамжуулах дамжлага биш.

–Дамжлага биш ээ? Тэгвэл “Канатикын” тухай хэн түүнд илтгээ вэ? Чи биш уу?

Варя таагаад буудчихсан боловч яг оночихжээ. Лёвочка нөгөө өрөө рүү буцаж очоод эргэж ирэхдээ,

–Өнөөдөр таван цагт Соёл амралтын паркийн үүдэнд хүлээж байя гэнэ гэж баргар царайтай өгүүлэв.

–Савлуур дээр савлах нь юм болов уу? гэж Варя доогтой асуув.

–Хэлсэн юмыг нь л дамжуулж байна.

–Та хоёр муудалцаа юу? гэж Рина зургаасаа хараа салгалгүй асуув.

–Чамд ямар хамаа байна!

–Зүгээр л тэгж байна...

–Тэгвэл дуугүй байж бай.

Варя Софья Александровнад санаа зовж байсан тул гэртээ ирэнгүүт давын өмнө тэдний рүү утасдав.

–Софья Александровна, юу болсон бэ?

–Бүх юм жин тан.

–Цаадах чинь нүүгээд явчихсан уу?

–Тэгсэн.

–Өөрийнхөө юмыг аваад уу?

–Тийм.

–Та яаж аргалаа вэ?

–Аргалсаан... Ирэхээр чинь ярьж өгөмз. Утсаар хэлье гэхгүй байна, тэр нь ч зүйтэй. Софья Александровна Костяг яаж аргалж гаргасныг мэдэхсэн гэж Варя тэсэж ядан байвч Нинаг ирэхийг хүлээж, цаашид яаж аж төрцгөөхөө тохиролцох хэрэгтэй байв. Дор дороо гэр бараална гэдэг бол айл хөршийнхөөсөө ичмээр муухай хэрэг.

Варя чемодантай юмаа гаргаж, даашинз сэлтээ хувцасны шүүгээнд хуучин дассан сурсан газраа өлгөөд ширээнийхээ шургуулгыг татаж үзвэл ингээд буцаад ирэхийг нь Нина мэдэж байсан юм шиг юу ч хөдөлгөж хөндөөгүй бүх юм хуучнаараа байв. Ямар ч гэсэн эгч нь, ямар ч гэсэн гэр нь, төрсөн гэр нь энэ шүү дээ. Тэрээр зургийнхаа самбарыг ширээн дээр сууриалаад ажиллаж эхлэв.

Ийнхүү ажиллаж байтал Нина ирэв. Варя түүн руу инээмсэглэн харж, юм идмээр байна уу гэж асуугаад ажил дээрээс авчирсан талхан зууш руу заав. Нина ч гэсэн эвийг бодож байгаа нь илэрхий, самбар луу очиж Варягийн юу зурж байгааг асуугаад тайлбарлаж ярьсан хариуг нь анхааралтай сонсов. Аж ахуйн тухайд тэр хоёр дор бурдээ ажил дээрээ үдийн хоол иддэг болохоор ямар нэг асуудал алга гэж Нина хэлэв. Гэвч байрны хөлс, утас, шатдаг хий, цахилгаан, өглөө, оройны хоол гээд олон юм байна, энэ бүхний зардлыг эгчтэйгээ яг адилхан хуваалцана гэж Варя зөрөв. Тэгээд дундын зардлаа бүртгэж байгаад сарын эцэст дүнгээ яг таллан хувааж төлж байхаар тохирцгоов.

Дараа нь Варягийн авчирсан талхан зуушийг идэж, цай ууцгааж элдвийг хүүрнэв. Варя зочид буудлын барилгын ажлын тухай, хамт ажилладаг хүмүүсийнхээ тухай ярьж, тийнхүү ажилдаа шохоорхон байгаа нь Нинад сайхан санагдав. Гэхдээ Костягийн тухай ганц ч уг цухуйлгасангүй. Нина ч бас цаг нь болохоор өөрөө аяндаа ярина гэж санаад тэр тухай асууж шалгаасангүй.

Бодвол бүр арван цагийн үед болов уу үүдэнд утасны хонх тасхийлээ. Нина утас авав.

–Варя, чамтай ярина гэнэ.

Нина түгшиж гайхсан янзтай түүн рүү харж байв. Тэгмэгц Варя Костя ярьж байна гэж мэдэв. Яг мөн байв.

–Лёва миний хүсэлтийг чамд дамжуулсан уу?

–Дамжуулсан.

–Яагаад ирсэнгүй вэ?

–Савлуур дээр тоглохоо больсон, нас өнгөрсөн.

–Чи бид хоёр ярилцах хэрэгтэй байна.

–Би сонсож байна.

–Утсаар ярих юм биш ээ. Уулзах хэрэгтэй байна.

–Бидэнд ярих ч юм байхгүй, уулзах ч шаардлага байхгүй.

–Маш чухал зүйл шүү. Надад ч, чамд ч, бас Софья Александровнад ч чухал.

Мэдээж худлаа л даа, сүрдүүлж байна. Тэгж бодсон хэрнээ сэтгэл зовоод явчихав.

–За яахав, маргааш дөрвөн цагт “Гранд-отелийн” тэнд очоорой, тэгээд ярилцъя.

–Үгүй ээ, одоо бушуухан ярилцах хэрэгтэй байна, энэ хичнээн чухал зүйл гэдгийг чи бүр төсөөлөхгүй байгаа, маргааш бол нэгэнт оройтчихно. Арбат руу хэдхэн минут гараад ир.

–За тэгье би одоо гарлаа гэж Варя хэлэв. Тэрээр өрөөндөө эргэж ороод цуваа нөмрөв.

–Би удахгүй ирнэ.

–Нөгөөдөх чинь уу? гэж Нина товчхон асуув.

–Тийм.

–Би чамтай явья, тэгэх үү?

–Яах гэж?

–Юмыг яаж мэдэх вэ... Варя инээд алдав.

–Санаа бүү зов.

Костя пальтоныхоо захыг босгож, саравчтай малгайгаа духдуулан дарж нэг харахад мөрдөн байцаагч шиг, нөгөө харахад америк киноны дээрэмчин гэлтэй амьтан тэдний байшингийн тэнд нааш цааш холхиж байв. Варя түүнийг ийм дүртэй байхыг огт хараагүй ажээ. Хачирхам мунхаг баг.

Тэр хоёр Арбатыг уруудав.

–Утас хэн авсан бэ?

–Эгч.

–Чамайг над руу явсан гэж мэдсэн үү?

–Мэдэлгүй яахав.

Тэд эхлээд Плотников руу, дараа нь Криво арбатын хөндлөн гудам руу эргэж, сургуулийн эсрэг талд байдаг хэсэг зай руу очиж урт сандал дээр сууцгаав. Харуй бүрий нэгэнт нөмрөн авч, гудамжны сүүтгэр дэнлүүнүүд зэгэлтэн, байшингийн цонхнууд гэрэлтэн ярайж, хөндлөн гудмаар ганц нэгхэн хүн хааяа явж өнгөрнө.

–Нөхрөөсөө тусдаа ресторан хэсэхийн хэрэг байхгүй, ямар ч эвгүй юманд орчихож мэднэ хэмээн Костя яриагаа эхэлж –Чи надтай хамт байсан бол хэн ч чамд халдах ёсгүй, гэтэл надгүй яваад тийм юманд өртчихсэн байна шүү дээ гэв.

–Чамаас өмнө надад нөхөр гээч юм байхгүй байхад хэн ч надад халддаггүй, хэн ч намайг доромжилдоггүй байсан. Тэр муу хүүхэн чинь намайг чухамхүү чиний эхнэр байсан учраас бас өөр шигээ банзал эм гэж үзээд доромжилсон хэрэг.

–Тэр чинь солиотой хүүхэн, өвчтэй хүн гэж Костя зөрөв.

–Ямар өвчтэй гэж?

–Галзуу солиотой гэж би чамд хэлж байна шүү дээ. Солиотой хүн чинь юу ч гэж донгосож мэднэ.

–Костя надад цаг алга, эгч маань хүлээж байгаа хэмээн Варя түүний үгийг тасалж,

–Тэр солиот чинь надад падгүй, бас “Канатикт” болсон явдал ч хамаа алга. Чи бид хоёрын зам нэгэнт салсан гэв.

Цаадах нь нэг хэсэг дуугүй байснаа гэнэтхэн инээмсэглэж Варягийн гарыг барих гэж оролдов.

–Байз л даа, Ляленька минь, битгий бухимд. Чиний ууртай байгааг би ойлгож байна, гэхдээ чи бид хоёр чинь тийм ч муугүй амьдарч байсан шүү дээ. Чи санасан бүхнээ л хийж байсан. Ажиллана гээд ажилд орсон, дээд сургуульд ормоор байвал би чамд тусална, миний дэргэд байхад чи уулын нөмөрт л байгаа гэсэн үг. Варя гараа татаж авав.

–Костя, чи хий горьдохын хэрэггүй. Бүх юм дууссан.

Костягийн уруул хорсолтой татвасхийв.

–Тэгэхгүй шүү! Намайг өрөө олтол чи хүлээнэ гэж амласан. Гэтэл би одоо гудамжинд гарчихлаа, хонох ч газар алга.

–Тэр худлаа. Би эгчийндээ байна уу, Софья Александровнагийнд байна уу, чамд ялгаа байхгүй гэж чи өөрөө хэлсэн шүү дээ. Чиний надад худалдаж авч өгсөн юмсыг би орхичихсон, түүнийгээ аваарай, бильярдынхаа мөрийд алдана уу, завхай хүүхнүүдийнхээ гарыг цайлгана уу, чиний дур. Тийм учраас чи бид хоёрт өгөө аваа байхгүй.

–Үгүй шүү, данс нийлээгүй хэмээн Костя ярвайж,

–Тооцоо нийлэх яагаа ч үгүй байгаа. Чи миний тухай Софья Александровнад юу хэлсэн бэ? гэв.

–Би юу? Юу ч хэлээгүй.

–Худлаа ярь!

–Би худлаа яриагүй. Зөвхөн нөгөө нөмрөгний тухай л хэлсэн, хэлэх ч ёстой байсан юм, тэгээгүй бол Софья Александровна сэргийлэхэд мэдүүлж чамд л муу юм болох байсан. Ер нь түүнд юм яриад байхын хэрэгцээ байхгүй, өөрөө бүх юмыг харж байгаа юм чинь. Чи гэрт нь буу авчрахгүй гэж амласан хэрнээ өчигдөр аваад ирсэн байна. Би энэ бүхнээс чинь залхаж гүйцсэн, тэгээд явчихсан юм. Чи яах санж вэ, дураараа болно биз.

–Би яахыгаа мэднэ, миний төлөө бүү санаа зов хэмээн Костя шазуур зууж,

–Би тэр хатагтайтай тооцоо хийхээ л нэг хийнээ, өгөх юмаа өгнө, тэр муу цусаар ханиах вий, гайгүй... гэж занав. Варя ойлгож ядан,

–Чи хэнийг хэлж байгаа юм бэ? гэж асуув.

–Чиний тэр хөгшин өлөгчин Софья Александровнаг хэлж байна. Тэрний хэлсэн зарим нэг юмыг би араандаа зуучихна аа гайгүй, тэгэхэд тэр муу миний өмнө сөхрөхгүй хаачих вэ дээ. “Манайд хууль ёс гэж огт алга, гагцхүү хууль завхруулга л байна...” гэсэн. Бас нөхөр Сталины тухай... Нэг муу хүүг нь шоронд хийчихсэн гэнэ, тэглээ гэж тэр авгай манай засгийн газрыг муулахдаа хүрч байна...

Варя түүнийг яахаас ч буцахгүй гэж бодож байсан боловч ингэнэ чинээ даанч санасангүй.

–Костя, чи юу ярьж байна аа! Бодооч!

–Та нар надтай яаж харьцана, би та нартай яг л тэгж харьцана. Муусайн хувцаснуудаа буцааж өгч гэнэ, тэгээд тооцоо нийлчих юм гэж бодоо юу? Гайгүй байлгүй!

–Өө муу, хүний адаг! хэмээн Варя багтран хашгичиж,

–Ховын хар тулам, чи ч тийм л амьтан болж таарч байх шив. Ховлох гээд үзээрэй чи! Чи Софья Александровнаг яаж ч чадахгүй, тэгж мэдээрэй! Түүний тухай ганц л үг цухуйлгасан

байх юм бол тэр ховыг чинь Софья Александровнагийн үг биш, чиний үг гэдгийг би нотлон гэрчилнэ, чи ойлгож байна уу, чиний үг гэж би нотолно. Би цорын ганц гэрч, тэгэхлээр чинийхийг биш миний хэлснийг үнэмшиж таарна. Софья Александровна гэртээ буу байлгахыг зөвшөөрөхгүй байсан гэтэл чи тусгай дэглэмтэй гудамжинд буу хадгалж байсан. Түүнээс болж Софья Александровнад өс санасандаа түүнийг худлаа гүжирдэж байгаа юм гэж би хэлнэ. Софья Александровнад хуруу хүрэх төдий халдсан байх юм бол би чамайг үнсэн товрог болгоно шүү. Тэглээ гээд чамд хэн ч тус болохгүй, нөгөө Рина, Лёвочка мэтийн найзууд чинь цөмөөрөө чамайг худалдчихна гэв.

Тэрээр уур, занал, хорсолдоо багтраад ярьж чадахгүй байв.

–Ярь, ярь, сүүлчийн удаа ярих чинь энэ хэмээн Костя дуугаа намсган шивнэж,

–Сүүлчийн удаа гэж мэд, яагаад гэвэл би чамайг одоо нам буудна! гэв.

Түүнийг ингэж хэлэнгүүт Варя хоромхон зуур тайвширчихлаа. Цаадах нь халаасандаа гараа хийсэн байхыг үзвэл нэг удаа өөрт нь үзүүлж байсан “Смит, Вессон хоёр” гэдэг гар буутайгаа байгаа хэрэг. Тэгэхэд тэр бууг нэг алдартай найзынх нь буу, засах гэж авчирсан юм гэж байсан юм, мэдээж худлаа хэлээ л дээ, дандаа худлаа ярьдаг юм чинь. Гэвч Варя түүнээс өчүүхэн төдий ч айсангүй, цаадхыгаа хулчийгаад буудаж чадахгүй гэсэндээ тэр. Софья Александровнаг ч ховлож чадахгүй, бас л хулчийна. Буудах гээд үзэг л дээ! гэж бодохоос Варягийн ид хав нь оргилоод ирэв.

–Өө тийм үү? Чи намайг буудаж алах нь уу? хэмээн Варя тамшаалж,

–Тийм учраас намайг хэн рүү явсныг эгч чинь мэдсэн үү гэж асуусан байх нь. Мэднэ, чам руу явсан гэж мэдэж байгаа, тэгэхлээр бууд л даа, хариуд нь буудахаар шийтгэнэ гэж мэдээрэй, тэр тухай санаа тавих хүмүүс бий. Муу хулчгар! Бууд л даа, муу хулчгар минь, бууд! гэж хашгичив.

Байшингийн энд тэнд цонхны хөшиг ярагдаж, хүмүүс харанхуй талбай руу харцгааж эхлэв... Варя,

–Аль вэ, буудаач, чи чинь яагаад буудахгүй байна, хулчгар новш! гэж дахин хашгичив.

–Хөөе, юу болоод байна аа? гэж нэг цонхоор эрэгтэй хүн чанга асуув.

Гудамд явж байсан хүмүүс зогтусан саатацгааж эхлэв.

–Битгий чарлаад бай, солиотой амьтан. Чи ямар ч байсан миний гараас мултрахгүй.

Костя огцомхон эргээд гудам өгсөн яаравчлан одов. Варяг гэртээ эргэж ирэхэд Нина,

–Би чамайг хайхаар завдаж байлаа. Нууц биш бол юу болсныг хэлэхгүй юу? гэв.

Варя инээд алдав.

–Гойд юм болоогүй ээ, буудна гэж сүрдүүлээд.

–Энэ чинь бас ямар гээчийн сонин болж байна! Хаана амьдарч байгаагаа тэр чинь мартчихаа юу? гэж Нина жигшин өгүүлэв.

–Тэр чинь ердөө л тэнэг толгой, өчүүхэн амьтан.

Маргааш нь Варя ажлаа тараад шууд Софья Александровнагийн очив.

Софья Александровна ширээний ард захиа бичээд сууж байв. Бодвол Сашад бичиж буй нь тэр байх.

–За Софья Александровна, яриад байгаарай, юу гээч болсон бэ?

Софья Александровна үзгээ хажуу тийш нь тавьж нүдний шилээ авав.

–Эндээс яв гэж түүнд тушаасан. Баахан цааргалж байснаа дараа нь яваад өгсөн.

–Үгүй, та нэгд нэгэнгүй ярь л даа.

–Би түүнд гэрт буу авчрахыг хориглоод байхад та авчирсаар байна, тийм учраас би Варяг загнасан, тэгсэн чинь эгч рүүгээ яваад өгсөн, таныг ч гэсэн эндээс явахыг би гуйж байна, түүнээс гадна танаас болж хаалганы гинжийг цүүлэхгүй байна гэж манай хөршүүд дургүйцээд байгаа гэж хэлсэн. Тэгтэл нөгөөдөх чинь муухай авирлан занаж, намайг энэ өрөөг дамладаг гэхчлэн элдвийг донгосож гардаг байна...

–Өөдгүй новш!

–Би тэгэхээр нь өнөөдрөөс эхлээд хаалганыхаа гинжийг цүүлнэ, танд хэн ч хаалга тайлж өгөхгүй, хэрвээ орох гэж зүтгэх юм бол цагдаа дуудаад, таныг эрхэлсэн тодорхой ажилгүй, буу дамладаг хүн, манай хөршийнхөн цөм энэ хүнд дургүй байдаг юм, бас юун хүн бэ? гэдгийг байрны захиргаа хэд хэдэн удаа асуусан, хэсгийн сэргийлэгч хүртэл сонирхож байгаа гээд хэлчихнэ гэж түүнд шулуухан хэлээд тавьчихлаа. Тэгсэн чинь намайг дахиад л сүрдүүлж байна. Би хариуд нь “Миний хүү баригдаж цөлөгдсөн, би прокурор, мөрдөн байцаагч, өмгөөлөгч энэ тэрийн алинтай нь ч уулзах замыг хэзээний мэднэ, та намайг юугаар ч сүрдүүлж чадахгүй, харин өөрийнхөө тухай бодсон чинь дээр байх, хэрвээ та маргааш өглөө манайхаас бүрмөсөн явахгүй бол хожим өөрийнхөө хар толгойд л гомдоорой, би яахаас ч буцахгүй шүү” гэж хэлчихээд гараад явчихсан юм. Өглөө нь нөгөөдөх чинь юмаа аваад яваад өгсөн.

–Өөрийнхөө юмтай юу? Минийхийг яасан бэ?

–Чинийхийг үлдээчихсэн.

–Эргэж ирэх шалтаг болгох гэж тэр.

–Чамтай эвлэрнэ гэж найдаж байж мэдэх юм.

–Тэр тухай горьдсоны гарз.

–Харин түүнийг түлхүүр орхино гэж даанч сэтгэлд багтахгүй байсан юм. Шинэ цоож тавиулах хэрэг гарах нь л гэж бодож байсан шүү гэж Софья Александровна хэлэв.

–Хашир нь тэр зэрэг хэмээн Варя тамшаалж,

–Хэрвээ танай байранд хулгай орох юм бол түлхүүртэй байсан хүмүүсийг л хардана шүү дээ, тэгээд л мань хүн түлхүүрийг чинь буцааж өгч байгаа нь тэр гэв.

–Магадгүй.

–Харин үлдээсэн юмны тухайд бол та санаа зовохын хэрэггүй, би гэртээ авааччихъя. Хэрвээ авах гэж ирэх юм уу утасдвал Варя юмаа аваад явчихсан, түүнтэй л ярилц гээд хэлчихээрэй.

–Тэр ч зөв шүү, чиний л хувцас юм чинь өөрөө л өмсөж эдлэх хэрэгтэй.

–Учир нь олдоно биз хэмээн Варя тодорхойгүй өчих зуур тэр хувцас хунарыг яг маргаашид нь багтаан Лёвочкагаар Костяд хүргүүлнэ гэж хатуу шийджээ.

Тэрээр Софья Александровнаг энхрийлэн тэврэв.

–Би таны өмнө түмэн буруутан, та надаас болж бөөн зовлон амслаа.

–Хүү минь, чи юу ярина вэ, тийм юм бодохын ч хэрэг байхгүй. Цаадхаасаа бүү ай, тийм хүмүүс зөвхөн доройд дээрэлхэж, аймхайд зориг гаргадаг юм.

–Би энэ тухай мэднэ, өчигдөр орой намайг гадагш нь дуудаж уулзаад ална гэж сүрдүүлсэн хэмээн Варя мушилзав.

–Нээрэн тэглээ гэж үү?

–Нээрэн тэгсэн, би түүнийг дооглочихоод яваад өгсөн.

–Сайн байна, яг тэгж байх хэрэгтэй!

Варя өөрөө ч гэсэн сайнаа мэдэрч, хүч амтагдан, хэнээс ч хамаарахгүй болсноо ухаарав. Нээрэн, эцсийн эцэст хэнээс ч хамаарахгүй болжээ! Тэрээр алдаж эндсэн ч гэсэн, оmtгойдож буруутсан ч гэсэн бусдын эрхшээлд оролгүй, учирсан бүх муухай явдлыг даван туулж чадлаа. Алдаж эндэх бол яахав дээ, эцсийн бүлэгт алдаанаасаа сургамж авдаг юм чинь. Энэ орчлон дээр хүмүүс хэрчим талхныхаа төлөө, байх суух газрынхаа төлөө чадлаараа үзэлцэж, хаа сайгүй нөхцөл байдалд зохицоцгоож байгаа юм чинь хүн төрхөө хадгалан үлдэж, нэр төрөө хэнд ч доромжлуулахгүй байх л хамгаас чухал буюу. Варя ингэж чадсан болохоор үүгээрээ бахархсан ч болох билээ.

–Та Сашад захиа бичиж байгаа юм уу?

–Тийм ээ, хүү минь, Сашадаа бичиж байна. Маргаашдаа багтааж явуулах хэрэгтэй болчихоод байгаа юм, зам боогдохоос өмнө хүрэхгүй байх гэж санаа зовж байна. Арав, арван нэгэн сард Ангара бүрэн хөлдчихөөр тэнд ямар ч харилцаа холбоо байхгүй болчихно. Түүнээс нааш сүүлчийн шуудан очиход Сашаг захиа заавал аваасай гэж бодсон юм.

Варя Сашаг алс холын Сибирийн их мөрний эрэгт орь ганцаар зогсож байгаа мэт төсөөлөн бодвоос өөрөө бас түүнд хоёрхон үг ч болохноо бичиж өчүүхэн боловч баярлуулмаар санагдав. Нөгөө тохиолдсон бүх шалгалт сорилтыг амжилттай даван туулсны дараа одоо мань бүсгүйн сэтгэл дахин ариусан шулуудсан болохоор өөрийн мэдэх хамгийн сайн хүн болж буй Сашад хэдэн үг бичихэд тун амархан байлаа.

–Би нэг хэдхэн үг биччихэж болох уу?

–Варенька минь, ер бололгүй яахав дээ хэмээн Софья Александровна баярлаж,

–Цаадхад чинь надаас өөр захиа бичих хүн огт байхгүй болохоор ёстой их баярлах вий гэв.

Варя нэг хуудас захидлын цаас авч бодолхийлснээ үзгээ бэхэнд дүрээд ингэж бичив.

“Сайн байна уу, Саша! Би одоо ээж дээр чинь ирчихээд бид хоёр чамд захиа бичиж байна. Манайхны ажил явдал, биесүүд цөм сайн байна, ээжийн чинь бие сайн, би Москвагийн зураг төслийн газар ажиллаж байна...”

Дахин бодолхийлснээ “Чиний одоо юу хийж байгааг мэдэж болдогсон ч болоосой...” гэж нэмж бичив.

Киров Сочид байхаас халширч гүйцэв. Тэрээр эх гаргагчдын бичсэнийг уншиж, Сталины сайшаасныг сайшааж байгаа болохоор сурах бичиг зохиох ажилд ёс төдий оролцож байв. Сталин зөвхөн өөрийнхөө биеийг өргөмжлөх зорилгын үүднээс төдийгүй өөрийнхөө өнгөрсөн, одоо, ирээдүйн харгис явдлыг зөвтгөхийн тулд түүхийг засварлан гуйвуулж байгааг Киров ойлгож байлаа. Гэхдээ зөрж чадсангүй, өөрөө түүхч ч биш, онолч ч биш болохоор онолын асуудлаар няцаалт өгнө гэдэг бол ямар ч утга учиргүй явдал болно, яагаад гэвэл ямар ч юмыг нотолж чадах онолчид, түүхчдийн бүхэл бүтэн сүрэг Сталины мэдэлд байна. Ийм юм руу хуруу дүрэхийн хэрэг байхгүй. Үүний хамтад Сталины Кавказад гүйцэтгэж байсан үүргийн тухай өгүүлэл бичиж байх нь бас зохисгүй.

Киров Азербайжаны намын байгууллагыг таван жил толгойлохдоо түүний түүхтэй нарийвчлан танилцсан болохоор Сталины Бакуд гүйцэтгэж байсан үүргийг сайн мэднэ. Сталин тэгэхэд жирийн нэг мэргэжлийн хувьсгалч л байсан юм. Гэтэл бусад олон зүйлийг санаанаасаа зохиож буйн нэгэн адил түүний Бакуд гүйцэтгэж байсан онцгой үүрэг гэгчийг одоо өнгөрсөн хойно дураараа зохиож байна. Киров өөрөө тэр ажилд оролцсоор ирсэн. Гэхдээ нөгөө асуудлууд нь бол намын түүхийн нийтлэг томоохон асуудлууд байсан, тухайлбал Сталин, Лениний залгамжлагч гэдэг нотолгоо намд чухал шаардлагатай байсан, тийм учраас Киров энэ нотолгоог хүлээн зөвшөөрч, үнэний замаас яльгүй хазайхаас өөр аргагүй болсон. Гэтэл бүх юм аль хэдийн болдгоо болчихоод тэмцэл дуусдагаа дуусчихаад байхад Сталинд “Нина” хэвлэх үйлдвэрийн толгойлогчийн титэм яагаад хэрэгтэй болов? Кировын өөрийнх нь гараар Енукизетэй тооцоо бодох гээ юу? Өөрөө ийм ажилд заяа нь оролцохгүй.

Тэрээр Бакугийн гудамж талбай, байшин барилга, үйлдвэрийн газар, өрөмдлөгийн цамхаг энэ тэрийг нэгд нэгэнгүй мэднэ, харин өөрийнх нь төсөөлж байгаагаар бол тэр үед Сталины нэртэй холбож үзмээр юм юу ч байгаагүй билээ. Одоо Баку тэр чигээрээ Сталины дурсгалт газар болж хувирч байна. Амьд Сталины шүү. Өдий төдий гудамж, район, нефтийн үйлдвэр, дээд дунд сургуулиуд түүний нэрэмжит болжээ. Тэр ч байтугай Сталин чухам аль өрөөнд байсныг хэн ч мэдэхгүй атал Баиловын шоронд түүний музей нээжээ. Өрөөний тухай түүнээс асуухаа айжээ. Тийм юм асуувал уг баримтыг битүүдээ өчүүхэн зүйл гэж үзэж байна гэж санаж болно, бас Бакугийнхан ийм дурсгалт газар байх шаардлагатай эсэхэд ер нь тээнэгэлзэж байна гэж бодож болно гэсэндээ тэр. Бүх асуудлыг өөрснөө шийдэж, экскурсээр яваа хүмүүс тэр музейг үзэхийн хамт шорон руу орохгүй байх ёстойг бодож гадагш нь хаалга гаргахад амархан нэг өрөөг сонгож авчээ. Энэ бүхэн худлаа зүйл гэдгийг Сталин мэдэх боловч музей байгуулчихаад үзэгчдийг цувуулаад л байна. Ер нь Сталины өнгөрсөн явдлын тухайд бодит байдал домог хоёрын зааг арилчихаад байгааг Киров нэг бус удаа анзаарсан төдийгүй Оржоникизе тэр хоёр энэ тухай ярилцаж ч байсан удаатай.

Харин Кировын тухайд бол энэ зааг арилаагүй, тэгээд ч мань хүн шинэ домог зохиох бодолгүй байгаа билээ. Сталин түүнийг Сочид байлгах гэж зүтгээд байна. Ингэж хайран цагаа үрэх ч гэж дээ. Уул нь Ленинграддаа л байвал зохих цаг, хүнсний тасалбарыг халах ажил тулгараад байгаа юм чинь. Дөрвөн сарын дараа ЗСБНХУ-ын иргэд талхаа чөлөөтэй худалдан авах болно. Энэ үйл явдал тоо томшгүй их гарз хохирол, гачигдал зовлон үзэж байж байгуулсан хамтралын байгууллын амьдрах чадвартайг батлан харуулж байна. Тийм арга

хэмжээг унагаж болохгүй, маш нягт нямбай бэлтгэх хэрэгтэй. Ялангуяа Ленинград шиг өөрийгөө талх тариагаар хангаж чаддаггүй районд нарийн бэлтгэл маш чухал. Тэгж байхын оронд мань хүн Сочид дэмий сууж байна.

Түүхийн сурах бичгийн тэмдэглэлд оруулах саналуудыг Киров тэнгисийн хөвөөнд нарлангаа уншиж байв. Унших ч гэж дээ, зүгээр л гүйлгэж хараад харсан хуудаснуудаа хажуу тийш нь тавьж, салхинд хийсгэчихгүйн тулд чулуугаар даруулна.

Шигүү төмөр тороор давхар хүрээлсэн нарлагааны газар эл хуль оргино. Торноос зүүн, баруун тийшээ хаалттай бүс. Нарлагааны газар луу орох хаалганы тэндэх харилцуур утастай шовгорт харуул бий, өөр нэг харуул гадуур хашааны дагуух цардмал замаар нааш цааш холхино. Энд зөвхөн зочид л усанд орж нарлацгаана. Сталин тэнгисийн усанд ордоггүй болохоор ийшээ ирдэггүй ажээ. Зуслангийн үйлчлэгчид, хамгаалалтын хүмүүс өөр газар усанд орцгооно.

Киров энд цорын ганцхан хүнтэй л тааралддаг байв. Тэр нь Москвагаас ирсэн шүдний эмч бөгөөд Кировыг хүндэтгэн тогтуухан талархуу харьцана. Гэхдээ бялдуучлан зулгуйдах нь үгүй. Зөөлхөн дуутай, намбалаг байрын энэ хүн усанд сэлэхдээ гарамгай, тэнгисийн ус, нар, элс гээд эндхийн бүх юм түүнд сайхан байгаа нь илэрхий. Киров хүмүүс баярлаж байхыг үзэхээрээ өөрөө дандаа баясдаг билээ. Хүмүүс мянган жилийн тэртээ ч баярлаж чаддаг байсан, газар дэлхий дээр амьдрал байгаа цагт хойшид ч баярлаж байх болно гэдэг нь мэдээж. Тэглээ ч гэсэн Киров өөрийн нүдээр харж байгаа зөвлөлтийн хүмүүсийн баяр бахдалыг өөрөө төлөөлж буй төр улстайгаа, барьж бүтээж буй нийгмийн байгуулалтайгаа холбохгүй байж яахин чадах билээ. Түүний харааг баясгаж буй мишээл, сонор чимж буй инээдэм бүхэн өөрт нь, төрөлх намд нь заяаж буй шан харамж даруй мөн, бас арга буюу гаргадаг хатуу ширүүн төдийгүй зарим үес догшин хэрцгий гэхээр элдэв шийдвэрийг нь зөвтгөж буйн илрэл болой. Тэрээр марксист хүний хувьд өргөн цартай сэтгэдэг боловч мянга мянга, сая сая хүний цаана заавал тодорхой нэр бүхий хүн бий гэж үзнэ. Түүний хувьд хуран цугларсан олон түмэн бол нэр зүсгүй бөөгнөрөл биш. Тэрээр индэр дээр гарахдаа өөрийг нь сонсож байгаа хүн болгонтой толгой дараалан ойлголцохыг эрхэмлэдэг бөгөөд түүний уран илтгэгчийн нууц чухам үүнд байдаг байж ч магадгүй.

Киров биечлэн шууд тулж ярилцахыг бас хэзээ ч үгүйсгэдэггүй, ямар ч ярианд дуртай оролцдог билээ. Тэгээд ч шүдний эмч түүнд бас аятайхан санагджээ. Тэр хоёр усны бүлээн, тэнгисийн ёроолын ундардаг хүхэрлэг булаг, Мацестын рашааны хүний бие махбодид үзүүлэх нөлөө гэхчлэн хамгийн ердийн юм ярилцав.

Липман аль ч юмны тухай эмчийн хувьд биш зүгээр л цуг яриа дэлгэж байгаа хүний байдлаар ярих нь Кировын сэтгэлд нийцтэй байв. Өөрийнхөө мэргэжилтэй холбоотой шүдний тухай ярихдаа хүртэл том, бага сойзны аль нь дээр байдаг, юугаар амаа зайлсан нь илүү байдаг гэхчлэн хамгийн жирийн юм ярина. Гэхдээ Липман хэнийг эмчилж байгаагаа нэг ч удаа хэлсэнгүй, Сталины нэрийг нэг ч удаа дурссангүй.

–Мацеста гайхамшигийг бүтээж байгаа рашаан хэмээн Липман өгүүлээд,

–Манай байрны хөрш гэж явж ч чаддаггүй, аргаа барсан тахир татуу нэг хүн байсан юм, гэтэл

Мацестын рашааны дараагаар арван наймт шиг гүйж харайлгадаг болсон гэв.

–Танайх сайхан байртай юу?

–Юу гэмээр юм бэ дээ... Нийтийн орон сууцанд арван есөн метр хавтгай дөрвөлжин аятайхан нэг өрөөтэй, төвөөс холгүй, Хоёрдугаар Мещанская гудамжинд байдаг юм. Өрөөндөө нэр заасан харилцуур утастай. Үнэнийг хэлэхэд манай хөршүүд тэр утсыг нийтийн хонгилд гаргаж тавих хэрэгтэй гэж шаардаад сэтгэл дундуур байдаг юм. Надад дургүйцэх юм байхгүй л дээ, хүмүүс тэр утсыг ашиглацгааж л байна биз. Гэвч Кремлийн Ариун цэврийн удирдах газар зөвшөөрдөггүй юм. Тэр утсыг тэднийх тавьж өгсөн, тэднийх л тэр утсаараа намайг өвчтөн рүү дууддаг юм.

Кремлийн эмч нарыг дууддаггүй, нэр сүртэй өвчтөнүүд дээр нь авчирч үзүүлдгийг Киров мэднэ. Тэгэхдээ чухам хэн рүү авч явж байгаагаа хэлдэггүй гэж байгаа. Оржоникизе “Миний эмчийг над руу авчирч яваа хэрнээ миний нэрийг хэлдэггүй гэнэ билээ. Гэхдээ эмч бол тэртэй тэргүй мэднэ. Яагаад гэвэл Иванов авах гэж ирсэн бол над руу гэсэн үг, Петров ирсэн бол Куйбышев руу гэсэн үг. Ийм л тоглоом наадаж байдаг болсон шүү дээ...” хэмээн инээдэм болгон ярьж байсан ажээ.

Салхи сэвэлзэж тэнгисийн мандал бидэртээд ирлээ.

–Эрэг хавиар далайн мөгөөрс их байх чинь салхи тавих нь ээ дээ гэж Киров хэлэв.

Тэр хоёр ханиндаа элсэн дээр хэвтэх буюу усанд сэлэх зуур, эсвэл усанд орсныхоо дараа биеэ арчицгаах зуур иймэрхүү юм ярилцана. Кировын дэргэд байгаа цааснуудыг эмч харж байгаа боловч түүнд саад болохгүйг хичээн сониуч зан үл гаргана.

Харин Киров тэр “Саналуудын” утгыг бараг шимтэж ойлгоё гэхгүй өнгөцхөн харна. Түүхийг аль тал руу нь хянан засварлаж байгаа нь тэртэй тэргүй тодорхой байгаа юм чинь дэл сул зүйлийг юу гэх нь ямар ч ач холбогдолгүй юм. Тэрээр Сталины тухай бодлогоширно. Сүүлийн жилүүдэд түүний тухай ер нь их бодож байгаа билээ. Харин Ленинградд байхад ажилдаа дарагдаад тэр бодол нь бүрхэгдэх явдал бий. Энд бол ажил алга, Сталин л байна. Киров түүнтэй өдөр болгон уулзаж байгаа болохоор түүний тухай зогсоо чөлөөгүй бодох болжээ.

Тэрээр энэ хэдэн жилд Сталиныг, түүний чиг шугамыг дэмжиж, түүний дайсантай тэмцэж, нэр хүндийг нь өргөлцөж яваа билээ. Хэдийгээр Сталины хувийн олон зан чанар өөрт нь эвгүй санагддаг ч гэсэн чин санаанаасаа тийнхүү дэмжиж ирсэн. Хувийн чанарыг улс төрийнхөөс салгаж чаддаг байх хэрэгтэй л дээ. Лениний шүүмжлэлийг тусгаж авч засарна гэж Сталины амласанд тэрээр тэгтлээ нэг их итгээгүй билээ. Харин намын доторх тэмцэл Сталины зан чанарын муу талыг хурцатган даамжруулсан гэдэгт Киров итгэж байсан юм. Тэгээд тэр тэмцэл дуусахтайгаа зэрэг эцсийн арга хэрэглэх шаардлага үгүй болно. Тэгсэн цагт Сталины муу зан хойч үеийнхэндээ талархан дээдлэх дурсгал үлдээхийг хүссэн их гүрний удирдагчид байвал зохих аливаа сайхан юманд байраа тавьж өгнө. Сталин бол тийм хүсэлтэй хүн.

Гэвч Кировын тэр найдлага биелсэнгүй. Харин ч байр суурь нь бэхжихийн хэрээр Сталин улам хүлээцгүй, улам адайр хорон зантай болж, далдуур хутган үймүүлж, намын удирдагч нарын хооронд яс хаяж, аюулаас хамгаалах байгууллагыг удирдлагын гол хэрэглүүр болголоо. Кировын тэнд Ленинградад бол ДЯАКГ-ын дарга Филипп Медведь мужийн намын хороонд захирагдаж байгаа, харин бусад мужийн намын дарга нарын ярианаас үзвэл орон нутгийн аюулаас хамгаалах байгууллагууд тэндхийнхээ намын удирдлагаас улам бүр хамаарахаа больж гагцхүү төвдөө захирагдан, улсын бүх албанд нэвчин шургалж, ховлох мэдээлэхийг гол арга болгож, коммунистуудыг хүртэл нэгийг нөгөөгөөр нь мөрдөж мөшгүүлж байна. Кировыг мөрдөөд байгаа тухай Мария хэд хэдэн удаа сэтгэл түгшин хэлж байсан. Мария яхав, хүний авгай юм чинь санаа зовох нь зүйн хэрэг, гэтэл Мариагийн эгч Софья 1911 онд намд элссэн, уужуу сэтгэлтэй хүлээцтэй хүн атал тэгж мөрдөж байгааг бас нотолсон. Киров тэдний ингэж сэтгэл зовниж буйг үндэсгүй зүйл гэж үзнэ. Ленинградад ийм байдал хэрхэвч байх ёсгүй, өөрийнх нь хамгаалалтын дарга Борисов хүмүүсийнхээ байршлыг дэндүү олон сольж байгаагаас болоод мөрдөж мөшгиж байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлдэг хэрэг. Москвад бол байдал шал өөр, тэнд түүний алхам бүрийг хянана, тэнд Улс төрийн Товчооны бүх гишүүнийг мөрдөн, хэн нь хэнтэйгээ уулзаж байгаа, хэн нь хэнийдээ очиж байгаа энэ тэрийг яг хянана. Энэ бүхэн хичнээн муухай билээ, намд ийм юм хэзээ ч байгаагүй, гэтэл одоо ийм болчихлоо, тэгээд үүний эсрэг яах ч арга байдаггүй. Сталины хардлага улам нэмэгдэж, хэнд ч итгэхээ больсон учир түүнтэй илэн далангүй ярилцах арга огт байхгүй, тэгж гэмээ нь нэг мэдэхэд өөрийн чинь эсрэг түүнийг ашиглачихна. Энэ бүхнээс болж эргэлзэн тээнэгэлзэх, сэтгэл түгших тэр ч байтугай арга барагдах байдал бий болж байна. Тэгсэн мөртлөө Сталины эсрэг сөрж болохгүй. Ийм эмгэнэлт байдалд хүрчихээд байна. Сталины аргыг зөвшөөрөх үндэс алга, гэтэл чиг шугам нь зөв юм. Тэрээр Оросыг аж үйлдвэрийн хүчирхэг гүрэн болгож хувиргалаа. Сталины эсрэг босно гэдэг бол улс орныхоо эсрэг, намынхаа эсрэг босно гэсэн үг. Тэгэхлээр хэн ч дэмжихгүй. Эсвэл хэн нэг хүн дэмжлээ гэхэд Сталиныг хэнээр солих вэ? Кировыг өөрийг нь Ерөнхий нарийн бичгийн дарга болгохсон гэдэг бодол олон хүнд бий. Гэвч өөрт нь энэ бол хэрэггүй зүйл, дааж давах ажил биш, өөрөө онолч биш, гагцхүү хувьсгалын практиктай хүн. Түүний идэр залуу хувьсгалч үеийн магадгүй хамгийн яруу тод дурсамж бол өөрийн гараар бүтээсэн гектограф (хэвлэх төхөөрөмж) юм. Түүн дээр оюутнууд ухуулах хуудас хэвлэдэг байсан билээ. Энэ нь намын үйл хэрэгт түүний оруулсан анхны бодитой, биетэй хувь нэмэр бөгөөд тэр төхөөрөмжөөрөө үнэнхүү бахархдаг байжээ. Тэрээр өөрийнхөө төдийгүй удирдаж байгаа хүмүүсийнхээ ажил хөдөлмөрийн ийм үзэгдэж харагдахуйц дорвитой үр дүнд ямагт урамшин баярладаг юм. Өөрөө намын гишүүн, коммунист хүний эрхэм нэрийг зүүж, намын өндөр итгэл найдварыг хүлээн яваа нь их юм, илүү юу ч хэрэггүй. Гэтэл Сталин Лениний нас барсны дараа түүхэн тавилангаар бүрэлдэн тогтсон намын удирдлага, Лениний өвийг Троцкий, Зиновьев нарын халдлагаас хамгаалан бататгасан удирдлагыг тоохгүй байна. Энэ удирдлагыг хамтын удирдлага гэж нэрлэхээ хэдийн больсон, энэ нь ч үнэхээр тийм юм. Намын удирдлага бол Сталин. Уул нь удирдлагын цөм үлдэх нь үлдсэн шүү дээ. Ленин адилхан л нам, улсын удирдлага байсан, гэхдээ өөрийг нь хүрээлж байсан цөмийг тоосоор ирсэн. Цөмийн дотор санал бодол зөрөх явдал алийг тэр гэх вэ, тэгсэн ч гэсэн тоосоор ирсэн. Сталин Улс төрийн Товчоог араар тавьдаг болчихоод одоо Жданов, Маленков, Берия, Ежов, Мехлис, Поскрёбышев, Шкирятов, Вышинский мэтийн хүмүүс Товчооны гишүүдээс дээгүүрт үзэгдэх боллоо. Сталин хуучин зиновьевынхны талыг баримтлагчдыг хяхаж хавчихыг өөрөөс нь шаардахдаа цаанаа ямар зорилго агуулж байгааг Киров дотор нь орсон мэт ойлгож байв. Аллага хядлага хийх ямар ч шалтаг алга байхад тийм

байдал үүсгэх гэж дэвэргэж байгаа нь тэр. Тэгэхдээ Сталин айлган сүрдүүлж, гагцхүү айлган сүрдүүлэх замаар л удирдан жолоодохыг санаархаж байна. Энэ бол түүний ганцаараа эзэгнэн захирах засгийг бэхжүүлэхэд хэрэгтэй зүйл. Гэтэл энэ нь чухам юунд хүргэх нь бүү мэд. Лениний зөвлөлгөөг үл дагаж Сталиныг Ерөнхий нарийн бичгийн даргын албан тушаалаас чөлөөлөөгүйгээс нам ямар алдаа хийснийг Киров одоо харамсан ухамсарч байна. Уул нь тэр ёсоор болгох хэрэгтэй байж. Троцкий намын доторх харш этгээд байсан юм чинь тэртэй тэргүй дийлж гарч ирэхгүй байсан. Зиновьев, Каменев хоёрт нам итгэхгүй байсан учраас тэр хоёр бас удирдлагад гарч ирэхгүй байсан. Тэгсэн бол намыг түүний жинхэнэ большевик жигүүр буюу өнөөгийн Улс төрийн Товчоо тэргүүлэх байсан юм. Тэр Товчоонд Бухарин, Рыков хоёрт төдийгүй Сталинд ч гэсэн зай олдох байсан. Гэхдээ удирдлагын эрх тэгш гишүүний л зай. Нээрэн, засахын аргагүй алдаа болжээ. Сталиныг зайлуулна гэдэг бол бүтэшгүй зүйл. Ямар нэг юм ойлгуулж итгүүлнэ гэдэг бол бас яг адил. Тэрээр нүд зайлуулахын тулд, арга саам хийхийн тулд хүнтэй санаа нийлж байгаа дүр гаргадаг бөгөөд улс төрийнхөө нүүдлийг тун алсуур тооцоолно. Енукизегийн эсрэг өгүүлэл бичих, Москвад шилжиж ирэх гэхчлэнгийн эхлээд харахад ямар ч хал балгүй мэт саналынх нь цаана ямар нэгэн хэтийн улс төрийн бодол байгаа. Сталин адайр зантай гэж Лениний бичиж байсан зөв. Гэхдээ Сталин бол бас тэвчээртэй, шургуу хүн, бодож товлосон зүйлээ ямагт эцэст нь хүргэнэ. Тэрээр засаг барих нууцыг мэднэ. Түүний шашны сургуульд эзэмшсэн хялбарчилсан учир зүйн ухаан, мөн тэр сургуулиас өвлөсөн сургаалыг үхширэн дагах үзэл бодол нь хүмүүст амархан ойлгогдож сэтгэлд нь аясан нийцдэг болой. Сталин өөрийнхөө мэдэхгүй, чадахгүй юм байхгүй гэсэн итгэлийг ард түмэнд үнэмшүүлж чадсан юм. Түүний сүр хүч ард түмэнд таашаагдаж энэ олон жилийн сүйрэл, иргэний дайн, намын доторх тэмцлийн дараагаар дэг журам тогтсон нь тэдний сэтгэлд бас нийцэж, ард түмэн энэ дэг журмыг Сталинтай адилтган үзэж байна. Ямар нэгэн юм өөрчлөх боломж хэдийн үгүй болжээ. Киров өөрөө юу яаж ч чадахгүй байгаадаа арга барагдан цөхрөлд автана.

Киров 1926 онд Ленинградад шилжиж ирэхдээ маш нарийн зорилттой тулгарснаа ойлгож байсан юм. Ленинградын коммунистууд Зиновьевын төлөө санал өгчихөөд байсан үе. Төв Хороо зохион байгуулалт, суртал ухуулгын бүх арга хэрэгслээ дайчилж байж тэднийг Зиновьевынхны сөрөг бүлгийн эсрэг, Арван дөрөвдүгээр их хурлын шийдвэрийн төлөө, Төв Хорооны чиг шугамын төлөө санал өгөхийг богино хугацаанд ятган үнэмшүүлсэн юм. Хэдэн түмэн коммунист өчигдөрхөн удирдлага болгож байсан үзэл бодлоосоо няцаж, өчигдөрхөн буруушааж байсан өөр үзэл бодлын төлөө санал өгсөн энэ явдал бол намын түүхэнд анх удаа тохиолдсон үйл ажил юм. Энэ үйл ажлыг мань Киров явуулсан билээ. Түүний энэ ялалт гашуун ялалт байсан. Тэгээд ч энэ хэдэн жилд бүх хүч чармайлтаа Ленинградын коммунистуудын нэр төрийг сэргээх, тэдний сэтгэлд суусан хир бургтгийг арилгахад чиглүүлсэн. Тэрээр намын дотор төмөр мэт хатуу сахилгатай байлгахын төлөө байгаа нь үнэн, гэхдээ саналаа хүлцэнгүй дуулгавартай өгдөг, үг дуугүй олон түмэн намд хэрэг байхгүй, тийм намын байгууллагыг удирдах хүсэл түүнд алга. Хувьсгалт Питер хот Октябрийн хувьсгалын өлгий чигээрээ, питерийн ажилчид Оросын ажилчин ангийн манлай чигээрээ, Ленинград Европын тэргүүний шинжлэх ухаан, тэргүүний урлаг, соёлын хот чигээрээ үлдэх ёстой. Чухам энэ учраас Шинжлэх ухааны академийг Москва руу шилжүүлэхийг эсэргүүцсэн юм. Гэвч Улс төрийн Товчоон дээр дэмжлэг олоогүй. Шинжлэх ухаан социалист байгуулалтад үйлчилж байгаа учраас тэр ажлыг удирдаж байгаа төвийнхөө дэргэд, ардын комиссаруудын газар, захирамжлах байгууллагуудынхаа дэргэд байх ёстой

гэсэн жирийн үзэл бодлыг Улс төрийн Товчоо удирдлага болгожээ. Киров үүнтэй санал нийлээгүй. Гэвч бусад нь Киров Ленинградаас зөнөсөн академичдыг хүртэл өгөх дургүй байна хэмээн инээдэм болгоод түүнийг дэмжээгүй билээ. Сталин ч бас инээж байсан. Гэхдээ Киров Ленинградынхны нэрээ хичээдэг зүйлийг хохироож байгаа аливаа юмны эсрэг байна гэдгийг Сталин сайн ойлгож байсан юм.

Ямар ч байлаа гэсэн Кировын өөрийнх нь бодлого үр шимээ өгсөн юм. Ленинградын коммунистуудын Арван дөрөвдүгээр их хурлын өмнө өгсөн саналыг ямар ч хор уршиггүй санаандгүй нэгэн тохиолдол, тэд нарын Сталинд эргэлзсэн явдал бол үндэсгүй зүйл, Сталины бодлого бол цорын ганц зөв бодлого гэдгийг тэрээр хэдэн жилийн турш тэдэнд зүй зохисоор шургуу ятган сэнхрүүлсэн. Гэхдээ Ленинградын коммунистуудыг үүнд итгүүлнэ гэдэг амаргүй байлаа. Ленинградын коммунистуудын улс төрийн түвшин өндөр. Энэ хэдэн жилд нударганчуудын хөрөнгийг хураахад гарсан нугалаа, “амжилтаас толгой эргэх” гэгчийн тухайд Сталины үнэмшил муутай ов мэх энэ тэртэй хутгаж байгаад хамтралжуулах ажил хийгдсэн. Энэ хэдэн жилд улс орон өлсгөлөнг үзлээ, бас хүнс болон бараа таваарыг маш чанд нормчлон хуваарилах журмыг үзэж өнгөрүүллээ. Киров ленинградчуудыг өл залгуулж байхын тулд Москвагийн ардын комиссарын олон газартай энэ асуудлаар удаа дараа зөрчилд орж байж чадах бүхнээ хийсэн. Гэхдээ Ленинград ч гэсэн намын өмнө хүлээсэн үүргээ биелүүлсээр ирсэн. Энэ хугацаанд Ленинград хорин таван мянгатын тоонд оруулан хөдөө тосгон, МТС, сангийн аж ахуйн улс төрийн хэлтэс, тээврийн байгууллага, таван жилийн тэргүүлэх барилга байгууламж руу хэдэн түмэн коммунистаа илгээсэн. Ленинградын намын гишүүн ажилчдын сор нь тийшээ явцгаасан. Нам улаан Питерээс ийм хохирол шаардаж авсныг чухамдаа түүний үүрэг ролийг буцаан сэргээсэн нь тэр гэлтэй. Тэгэхлээр Арван дөрөвдүгээр их хурлын өмнө санал хураахад тохиолдсон явдал, түүнээс улбаалан үүссэн Ленинградын коммунистуудад үл итгэх хандлага энэ тэр үүрд сох мартагдсан гэсэн үг.

Гэтэл ийнхүү шарх нь аньж, өвчин нь намдчихсан байхад Сталин түүнийг дахин сэдрээхээр шийдэж, найман жилийн хойно Ленинградынханд тэр нэгэн явдлыг нь сануулж, өшөөгөө авч залхаан цээрлүүлэх гэж байна. Сталины “зэвсгээ орхиогүй болон нуугдчихаад байгаа хүмүүсийг устгана” гээд байгаа шаардлагын цаана Ленинградын намын байгууллагын гол нурууг хугалах гэсэн эрмэлзэл байгаа юм. Киров хэрхэвч тэгүүлэхгүй. Улс төрийн Товчоо өөрийг нь дэмжинэ. Сталин ч гэсэн ийм асуудлаар өөрөө шууд ил зөрчилд орохыг бодохгүй, Улс төрийн Товчоо түүнийг дэмжихгүй гэдгийг ойлгож байгаа. Сталин Намын Төв Хороо, Улс төрийн Товчоог өөрийнх нь хүсэл зоригийг үг дуугүй гүйцэтгэгч болгон хувиргаж чадахгүй. Тэгэхлээр энэ бол Сталин хэзээ ч намын дээр гарч чадахгүй гэдгийн баталгаа юм.

Сталин улс орныг шинэчлэн байгуулахад их зүйлийг хийж, аливаа аугаа их түүхийн зүтгэлтний нэгэн адил эрин үедээ өөрийнхөө ул мөрийг үлдээж байна. Ленин бол энэ шинэчлэн байгуулах ажлыг арай зохистой аргаар хийх байсан юм. Гэвч Ленин алга, Сталин байна. Ленин шаахай өмсдөг байсан, Сталин цэргийн савхин гутал өмсөж байна. Гэхдээ Орос орон дэлхийн аж үйлдвэржсэн хүчирхэг орны нэг, тэргүүний шинжлэх ухаан, хүчит техник, өндөр соёлт орон болж байгаа нь эргэлзээ алга. Алан хядах аргаар энэ орныг удирдаж болохгүй. Шинжлэх ухаан, соёл, техник бол оюуны чөлөөт солилцоог шаардана. Хүчирхийлэл улс орны хөгжлийн замд заавал саад тотгор болно. Түүхийн бодит хууль салангид бие хүнээс хамаагүй дээгүүр, хамаагүй хүчирхэг гэж марксизм сургадаг. Түүхэн үйл

явцын учир зүй юунаас ч хамаарахгүй. Сталин энэ учир зүйд захирагдахаас өөр аргагүй болно. Түүхэнд зам тавьж өгч аж үйлдвэр, шинжлэх ухаан, соёлыг хөгжүүлж, ажилласан шиг ажиллах хэрэгтэй, харин тэгэхдээ аливаа хэтрүүлэх аргыг эсэргүүцэн няцааж байх шаардлагатай нь мэдээж.

Гол нь... Киров хэвтэж залхсан тул бослоо. Гол нь намынхаа боловсон хүчнийг хайрлан хамгаалах явдал. Үндсэн большевик боловсон хүчнүүд амьд, хүчтэй байгаа цагт нам дийлдэшгүй дархан хэвээр байх болно.

–Та арай дэндүү шарчихжээ гэж Липман өгүүлээд,

–Цамцаа өмсчих, дараа нь хэрэгтэй бол... гэтэл жижүүрийн шовгорт утас дуугарав.

Киров, Липман хоёр тэр зүгт эргэж харав. Жижүүр Липман дээр хүрч ирээд эмчийг нэгдүгээр байр луу ирээч гэж байна гэж хэлэв.

–Дараа нь арьсаа спиртээр арчих хэрэгтэй, тэгвэл өвчин орохгүй хэмээн Липман түргэн хувцаслах зуур Кировт хэлэв.

Липман Сталины буйлыг шалгаж үзээд сайхан эдгэрч байгаа учир хоёр хоногоос хиймэл шүдээ хийж эхэлнэ гэж түүнд хэлэв.

–Маргааш бол болохгүй юу? гэж Сталин асуув.

–Маргааш ч байсан болно, гэхдээ нөгөөдөр бол дээр гээд Липман инээмсэглэв.

–Тэгвэл дураараа болохоос хэмээн Сталин хөмсөг зангидсанаа,

–Таны ажил юу болж байна гэж асуув.

–Хэв авсныхаа дараа л ажиллаж эхэлнэ дээ.

–Таны нөгөө ном бичих ажлыг хэлсэн юм гэж Сталин уцаарлан өгүүлэв.

–Уучлаарай, ойлгохгүй л будилж байна... Баярлалаа, бичиж л байна.

–За баяртай гэж Сталин босонгоо хэлэв.

Сталины дургүйг эмч биш Киров хүргээд байгаа билээ. Тэд дахиж үг сөрөөгүй, Киров түүхийн тэмдэглэлийн талаар санал хэлэлцэх үед тухай бүр ёсчлон ирж, бүх юмыг чимээгүй зөвшөөрч байвч өөрт нь хэрэггүй, сонирхолгүй ажил албадан хийлгэж байгаа хүн гэдэг нь андашгүй. Ингэж уулзаж байх нь тун яршигтай байлаа. Сталин Кировыг буцаачихаж чадах байсан боловч илт муудалцахыг хүссэнгүй. Тэвчих хэрэгтэй тул Сталин тэвчиж байв. Гэхдээ дотор тун бачуухан. Гаднаас нь харахад юу ч болоогүй мэт уужуу тайван царайлж байхад хичнээн их хүч зарцуулж байгааг гагцхүү өөрөө л мэднэ. Тэрээр ганцаараа байхдаа л биеэ барьж чаддаг хүн, тиймгүй бол олны өмнө тайван байж чадахгүйсэн билээ. Хэрвээ өөрийн эрхгүй уураа гаргахдаа хүрсэн бол тэр уурлуулсан хүндээ биш өөр хүнд гаргана. Энэ удаа эмчид уураа гаргаж таарчээ.

Липман товлосон цагт ирж гөлтгөнөөр хэв авах ажилдаа оров. Сталин хэв авахад дургүй, хэвтэйгээ хамт үлдсэн хэдэн шүдийг нь булгалж байх шиг санагддаг тул эмч амнаас нь гөлтгөнөө эмтэлж авахад дургүй, аман дотор нь гөлтгөнийн өөдөс өртөхөд дургүй...

–Юм юм л аятайхан байх шиг байна, муугүй болж байх шиг байх юм. Гэхдээ ямар ч атугай энгийн хиймэл шүд хийвэл ямар вэ, Иосиф Виссарионович ээ? гэж Липман асуув.

Сталин сандлын тохойвчийг шааж,

–Би алтан шүд хийлгэнэ гэж танд орос хэлээр хэлсэн биш үү! гэв.

–Тэгье, тэгье, таны хэлснээр л хийе, маргааш өглөө гэхэд бэлэн болно гэж Липман яаран өчив.

Липман гар нь салганан багаж хэрэгслээ эмхэлж буйг Сталин чимээгүй ажиглав. Айчихаж,

годил чинь! Ямар хаашаа улс вэ!

Липман юмаа эмхлэхээ гэнэтхэн больж хулчгар дуугаар,

–Иосиф Виссарионович, би шүдний өнгө тааруулж сонголт хийх ёстой юм, та дахиад жаахан суузнана уу гэж царайчлан гуйв.

Сталин дахин гэдийж түшүүрийг дэрлээд амаа нээв. Липман санаа зовсон төдийгүй бүр айчихсан царайтай нэг нэгээр нь ээлжлэн хэд хэдэн шүд жишиж зөндөө удаан ноцолдсонд Сталин амаа ангайж суухаас залхаж гүйцээд,

–Та мөд салах нь уу? гэв.

–Одоохон болчихно гэж Липман сунжруулан өгүүлэх зуур дахин хэдэн үлгэр жишиж үзэв. Тэгснээ ямар нэг шийд гаргав бололтой,

–Иосиф Виссарионович, та одоо босож болно. Би өглөө гэхэд бэлэн болгохыг хичээе гэж чемоданаа хаах зуур санааширсан байдалтай хэлэв.

Сталин маргааш өглөө нь эмчийг дууд гэж тушаав.

–Нөхөр Сталин, эмч шүдээ хийж дуусаагүй, маргааш гэхэд бэлэн болно гэж хэлсэн гэж Товстуха мэдэгдэв.

Сталины царай барайгаад явчихав.

–Түүнийг над руу дууд.

Хэдэн минутын дараа Липман аахилсаар орж ирэв.

–Та өнөөдөр шүд хийж өгнө гэж надад амласан. Яагаад амласнаа биелүүлсэнгүй вэ?

–Болж өгсөнгүй, Иосиф Виссарионович.

–Юунаас болоод саатаж байна? гээд Сталин хүн болгоны айдаг нөгөө нүсэр муухай харцаараа эмч рүү харав. Липман юм хэлж чадсангүй.

–Үнэний нь хэлээрэй.

–Ийм юм болчихлоо хэмээн Липман хулчгархан өгүүлж,

–Миний Москвагаас авчирсан бүх шүднээс нэгнийх нь ч өнгө таныхад таардаггүй ээ гэв.

–Таарах өнгө яагаад авчраагүй юм бэ?

–Манайд байсан бүх шүдийг авчирсан юм. Танд хуучин хэрэглэж байсан өнгөнөөс хүртэл авчирсан.

–Тэгээд яагаав?

–Хүний шүд, ялангуяа тамхи татдаг хүний шүдний өнгө хувирчихдаг юм. Миний авчирсан шүдний өнгө таныхтай тун ойрхон байгаа, тэглээ ч гэсэн яльгүй зөрөө байна.

–Их мэдэгдмээр юм уу?

–Гайгүй. Гэхдээ мэргэжлийн хүн бол анзаарна.

–Мэргэжилтнүүд надад ямар пад байна?

–Намайг таны шүдийг муу хийж гэж хэн нэг хүн битгий хэлээсэй гэж бодсон юм.

Сталин тамшаалж,

–Таны нэрээ хичээж байгаагаас болоод би шүдгүй явж байх ёстой болох нь. Одоо тэгээд хичнээн ингэж явах болж байна?

–Би хэрэгтэй шүдний ноймерыг жагсаалтаас олоод Москва руу утасдаж авчруулж өгөхийг гуйчихаад байна.

Сталин Липманыг нэвтрэх мэт ширтэв.

–Үгүй, та чинь Москвад байгаа бүх юмыг авчирсан гээ биз дээ!

–Олно л доо...

–Хаанаас олох юм бэ? Липман доогуур харсан чигээрээ,

–Берлинээс гэж өчив.

–Берлинээс ий!

–Би герман жагсаалтаас сонгож захиалсан юм.

–Та яагаад надад шууд хэлсэнгүй вэ? Липман дуугарсангүй.

–Битгий хэлээрэй гэсэн үү? гэж Сталин хямсайв. Липман дуугарсангүй.

–Хэн хориглоо вэ? Липман дуугарсангүй.

–Товстуха юу?

Липман мэдэгдэм төдий толгой дохив.

–За тэгэхлээр та нэг юмыг мэдэж ав хэмээн Сталин нухацтай өгүүлж,

–Нөхөр Сталинд бүх юмыг ярьж БОЛНО, нөхөр Сталинд бүх юмыг ярих ХЭРЭГТЭЙ, нөхөр

Сталинаас юу ч нууж БОЛОХГҮЙ. Түүнээс гадна нөхөр Сталинаас ЮУ Ч НУУХ АРГА БАЙХГҮЙ. Нөхөр Сталин эрт орой хэзээ боловч үнэнийг мэдэх л болно гэв.

Хиймэл шүд саатаж байгаа нь мэдээж эвгүй хэрэг, гэхдээ эцсийн бүлэгт үүний учир олдоно. Харин эмчийг хүчээр худлаа хэлүүлнэ гэдэг бол жигшүүртэй хэрэг. Түүний орчинд байгаа хэн боловч худлаа ганц үг ч хэлэх эрх байхгүй. Бага худлаас их худал үүснэ. Хэрвээ түүний орчны хүмүүс яль бүл юмаар худлаа хэлж байгаа бол найдваргүй хүмүүс гэсэн үг. Улс төрийн Товчооны гишүүдээс авахуулаад гал тогоонд байгаа тогооч хүртэл бүх хүн нөхөр Сталинд үнэнийг гагцхүү үнэнийг, зөвхөн үнэнийг ярих хэрэгтэйг мэдэж байх ёстой.

Тэрээр эмчийг явуулчихаад Товстухаг дуудав.

–Та яах гэж эмчийг албадаж намайг хууруулав?

–Ийм юм болжээ хэмээн Товстуха өгүүлж,

–Эмч өчигдөр таарах өнгийн шүд өөрт нь алга, тийм шүд зөвхөн Берлинээс л олж болно гэж хэлсэн юм. Би тэр дор нь Литвиновт утасдаж, жагсаалтын бүх зүйлийг уламжлаад Литвинов Хинчукт утасдсан юм... гэв.

–Хинчук Берлиндээ л байгаад байгаа юм гэж үү?

–Тийм, Суриц дөнгөж өнөөдөр л тийшээ гарна.

–За аа... Тэгээд?

–Бүх юмыг худалдаад авчихсан, өнөөдөр Москвад авчирна гэж Литвинов надад мэдэгдсэн. Орой гэхэд материал энд байж байна гэж найдаж байна, тэд нар шөнөдөө багтаагаад хийчихнэ гэж эмч хэлсэн.

–Тэд нар шөнө унтвал таарна, шөнө ер олигтой юм хийж чадахгүй. Харин та яах гэж эмчийг албадаж намайг хууруулав? гэдэг асуулт байна.

Тун санамсаргүй хариулт өчив.

–Берлинээс материал захиалахыг таныг хориглоно байх гэж би айсан юм.

Товстуха түүний даруу зангаас болгоомжилсон байх нь. Мөн ч адтай зусардана шүү! Эсвэл үнэхээр тэгж бодсон юм болов уу? Аз мэдсэн хэрэг гэж бүх юмыг өөрөө үүрэхээр шийдсэн юм болов уу? Шалгарсан үнэнч хүн юм чинь. Тэглээ ч гэсэн амиа аврах гэж ч худлаа ярьж болохгүй!

–Та өчигдөр надад хэлэлгүйгээр бүх юмыг хийжээ, тэгэхлээр би ниргэсэн хойно хашгирах гэгч шиг болж байна гэж Сталин өгүүлээд,

–Би таны үйлдэлд дургүйцлээ ч гэсэн өнөөдөр түүнийг өөрчилнө гэхэд нэгэнт оройтжээ. Харин та яах гэж эмчийг албадаж худлаа хэлүүлэв? гэж асуув.

–Түүнийг танд хамаг юмаа ярьчихна, тэгээд та хориглочихно гэж болгоомжилсон юм.

Сталин сэрүүвчин дундуур нааш цааш алхалснаа зогтусаж дахиад жаахан бром хэрэглэвэл муугүй байхсан гэж гэнэтхэн бодов. Енукизегийн нөгөө олиггүй өгүүллээс хойш түүний нойр муудсан билээ. Киров Енукизед няцаалт өгөхөөс зайлсхийгээд найдвар биелүүлсэнгүй, түүнийг Сочид байснаар мэдрэлийн систем тайвшрах янз алга. Гэхдээ тоймтой зүйлийг аар саар юмнаас салгах хэрэгтэй. Яль бүл юмнаас болж багтран шатахын хэрэг байхгүй. Берлинээс шүд захиална гэдэг бол өчүүхэн, яль шальхан зүйл! Товстуха хүн аргагүй үнэмшмээр чин санаанаасаа ярьж байна. Тэглээ ч гэсэн худал хуурмаг явдлыг үүсэл төдий байхад нь үүрд тас цохих хэрэгтэй!

Сталин царай нь дахин барайж Товстуха руу дөхөж очоод түүнийг нэвт цоргих мэт ширтэв. Товстуха час улайгаад нэг алхам ухартусав.

–Намайг хууран мэхлэгч нар хүрээлж байхыг би хүсэхгүй байна, намайг хүрээлж байгаа хүмүүст би туйлаас итгэж байх ёстой! Намайг хүрээлж байгаа хүмүүс аар саар юман дээр ч худлаа хэлэх ёсгүй, тэдний толгойд ч тийм бодол орж ирэх ёсгүй!

Сталин сүүлийн хэдэн үгээ нэлээд зөөлөн аястай хэлэх шиг Товстухад санагдав.

–Намайг уучлаарай, би дутуу зуурам юм хийсэн байна.

Гэтэл Товстуха эндүүрсэн байв. Сталин догшин харцаар түүнийг дахин өөд уруугүй цоргив.

–Өчүүхэн төдий ч гэсэн худлаа хэлсэн байвал би хатуу шийтгэнэ. Ялангуяа үйлчилгээний хүмүүсийг албадаж худлаа хэлүүлж байгаа этгээдүүдийг бүр ч хатуу цээрлүүлнэ. Та ойлгосон байлгүй?

–Ойлголоо, нөхөр Сталин, ийм явдал дахиж гарахгүй.

Маргааш нь үдийн хоолны дараа Товстуха эмчийн бүх юм бэлэн болсныг илтгэв.

–Хүрээд ирэг.

Липман гэлбэлзэн инээмсэглэсээр орж ирэн мэндлээд чемоданаа онгойлгов.

Сталин эмчийн юу хийж байгааг ажиглан өрөөн дундуураа холжих зуур,

–Бид хоёрын өчигдрийн яриаг та эргэцүүлж бодсон биз? гэв.

–Бодолгүй яахав, Иосиф Виссарионович.

–Би энэ тухай нөхөр Товстухатай ярьсан, тэгсэн чинь тэр нөхөр таныг албадаж худлаа хэлүүлсэн юм байна.

Липман зүрх тус гараа наманчлан дарав.

–Нөхөр Сталин бид танд худлаа хэлэх гээгүй юм! Нөхөр Товстуха яльгүй юмаар таны урмыг хугалахгүй гэсэндээ намайг таны санааг битгий зовоогоорой гэж гуйсан юм. Худлаа хэлж яаж болох билээ, тэнгэр минь.

–Санаа зовоох, урам хугалах энэ тэр чинь нялх хүүхдийн яриа, гэтэл та бид нар чинь том улс шүү дээ.

Сталин олбогт сандалдаа сууж толгойгоо гэдийн түшүүрээ дэрлэхэд Липман шинэ хиймэл шүдээ аягатай усанд зайлж сэгсрээд эвлэгхэн хөдөлж аятайхан байрлуулав. Энэ хэлхээ шүдийг алтан сэнжтэй хийжээ.

Дараа нь хиймэл шүдээ эвлүүлж суурилуулахаар харандаа, хөх цаастай ердийн ажил эхлэв... Шүдээ хаз даа. Ангай даа... Шүд нь эвтэйхэн сууж таарсан тул эвэнд нь оруулах ажил төдийлөн удсангүй.

–Юм юм нь болчихсон юм шиг л байна гэж Сталин өгүүлэв.

Липман явахдаа хиймэл шүдээ маргааш өглөө болтол авахгүй байхыг захиад, ямар нэг юм тээглэж баривал өөрийг нь дуудуулаарай гэв.

Хиймэл шүд нь тун эвтэйхэн таарсан тул түүнийг дуудуулах хэрэг гарсангүй. Сталин сэтгэл хангалуун байсан тул хоёр хоногийн дараа Липманыг хүрч ирэхэд,

–Шүд маань тун эвтэйхэн байна, энд тэнд нухалж зовоож байгаа юм ер алга. Яг л аль хэзээнээс зүүж яваа юм шиг байна гэж хэлжээ.

Тэгсэн ч гэсэн Липман түүнийг суудалд нь гуйж суулгаад хиймэл шүдээ авч буйлыг нь шалгаж үзсэнээ буцааж хийгээд,

–Нээрэн, дажгүй болсон юм шиг байна гэж нотлон өгүүлэв.

–За тэр дээ, гэтэл та алтаар хийхийн эсрэг байсан шүү гэж Сталин хэлэв.

Липман чимээгүй хэсэг тээнэгэлзэж байснаа,

–Нөхөр Сталин, та миний ажлын тухайд сэтгэл ханамжтай байгаа бол би нэг бяцхан зүйлийг гуймаар байна гэв.

–Тэг л дээ хэмээн Сталин хөмсөг зангидав. Тэрээр шууд өөрт нь хүсэлт тавихад дургүй билээ. Энэ талаар тодорхой журам бий, бас хариуцсан хүмүүс бий, тэд нар асуудлыг бэлтгэдэг, ямар хүсэлтийг түүнд танилцуулах хэрэгтэй, ямыг хэрэггүйг тэд мэднэ. Өөрт нь шууд биечлэн хүсэлт тавина гэдэг бол даруу бус явдал.

Хүсэлт нь санаандгүй зүйл байв.

Липман чемоданаасаа боолттой юм гаргаж задлахад дотроос нь нэг тагнайтай хиймэл шүд гарлаа.

–Нөхөр Сталин, энэ шүдийг хийгээд ганц өдөр болохыг би танаас гуйх гэсэн юм. Аль нь эвтэйхэн байх нь вэ, та үзээрэй, тэгээд өөрөө шийднэ биз.

Сталин гайхахын ихээр гайхаж нүдээ бүлтийлгэв. Алтан сэнжтэй нь дээр гэж түүнд тов тод хэлээд зогсоогүй, сандлаа хүртэл шааж авсан шүү дээ, тэгэхэд ухаан нь уландаа ортол айж байсан биш үү. Тэгсэн хэрнээ өөрийнхөөрөө муйхарлаж зүтгээд байх юм. Хаашаа янзын хүн бэ, нээрэн тэр нь хэрэгтэй юм болов уу.

–За яахав хэмээн Сталин дурамжхан зөвшөөрөв. Липман шүдийг сольж хийв. Тохируулах ажил түрүүчийнх шиг түргэн бүтэв. Юм юм нь л аятайхан байх шиг.

–Та намайг маргааш дуудуулаарай, тэгээд аль нь эвтэйхэн байгааг хэлээрэй. Аль эвтэйхэн байгааг нь л орхицгооё.

Маргааш нь үдийн хоолны өмнө Сталин Липманыг дуудуулав.

–Өөрийгөө шүүмжлэх журмаар үнэнээ хэлэхэд таны зөв байсан байна. Энэ шүдтэй байхад хөнгөхөн эвтэйхэн байна. Гэтэл энэ чинь эвдэрчихэж болно шүү дээ. Нөөцийн нэгийг хийж өгөөрэй.

Липман баярлан малилзав.

–Тэгэлгүй яахав, арвыг ч хийсэн хамаа алга.

–Өглөөний хоолоо идсэн үү?

–Идэлгүй яахав.

–Тэр яахав, надтай ханиндаа бас нэг юмхан гоочилчих.

Сталин түүнийг хажуугийн өрөө рүү дагуулж оров. Ширээн дээр дарс, зууш энэ тэр байх ажээ.

–Надад архи, коньяк энэ тэр байхгүй, би өөрөө ч уудаггүй, бусдад ч зөвлөдөггүй юм. Харин дарс бол шал өөр хэрэг. Та алинд нь дуртай вэ?

–Би дарсны тухай тун маруухан мэдлэгтэй шүү гэж Липман самгардаж өчлөө.

–Тоогүй хэрэг, дарсны тухай мэдэж байх хэрэгтэй. Би кофе огт уудаггүй, цай ууна, гэхдээ ховорхон. Дарсыг дээр гэж үздэг юм. Хоёр гурван хундага дарс бие сэргээдэг хэрнээ толгой манаруулдаггүй юм.

Тэрээр архиных гэмээр хоёр жижигхэн хундаганд дарс хийв.

–Таны хийсэн хиймэл шүд урт наслах болтугай. Юм идээрэй.

Липман нухаштай талхан зууш авав.

–Сочид дахиад жаахан амармаар байна уу? гэж Сталин асуув.

–Энд ёстой сайхан юм, гэвч би Москва руу, ажил руугаа буцах ёстой, танд л энд дахиад миний хэрэг гарахгүй бол тэр шүү дээ.

–Би таныг саатуулчихсан гээд дарга нарт чинь хэлчихнэ. Эндээ хэсэг байж, усанд орж, номоо бич л дээ.

–Намайг Москвад өвчтөнүүд маань хүлээж байгаа. Заримынх нь хиймэл шүдийг нь салгаж, заримынх нь өвчтэй шүдийг авах зэргээр эмчлээд эхэлчихсэн, тэд нар онгорхой амлаад намайг хүлээгээд сууцгааж байгаа. Яадаг юм билээ?

–Тэгвэл ч аргагүй шүү хэмээн Сталин түүний хэлснийг зөвшөөрч, –Хэзээ нисэх бодолтой байна? гэв.

–Аль болохоор түргэн. Маргааш бол сайн л байна. Сталин албан өрөөнийхөө хаалгыг нээж Товстухаг дуудав.

–Эмчийг маргааш Москва руу онгоцоор явуулаарай, шаардлагатай бүх юмаар хангана биз гээд Сталин дарс руу зааж,

–Жишээлбэл энэ дарс... гэв.

Тэрээр нэг тийшээ гарч дүүрэн усан үзэмтэй том сагстай буцаж ирээд Липманд өгөв.

–Даана биз дээ? Даахгүй бол хүн тусална гээд тэрээр Товстуха руу эргэж,

–Москвад тосож аваад гэрт нь хүргэж өгөг. Баяртай, эмч ээ! Эсэн мэнд яваарай! гэв. Сталин эмчийг явуулчихаад Киров, Жданов хоёрыг өөр лүүгээ урихыг тушаав.

Түүхийн сурах бичгийн ээлжит бүлгийн талаар эх гаргагчдын боловсруулсан саналуудыг Жданов илтгэв. Сталин өрөөн дотуур холхих зуур түүнийг сонсож, Киров явган ширээний ард цаасан дээр нэг юм зурж сууна. Сталин өөрөө хүнийг сонсохдоо юм зурах буюу сараачих зуршилтай хэрнээ Кировын тэгж байгаад цухалдан байв. Өөрийнх нь тэр зуршил анхаарлаа төвлөрүүлэх арга байсан бол Кировынх өөрийгөө саатуулж, энэ бүхэн өөрт нь төдийлөн сонирхолгүй харш зүйл гэдгийг үзүүлж байгаа арга юм.

Сталин дургүйцэж буйгаа юугаар ч сэжиг өгөөгүй төдийгүй Ждановыг илтгэж дуусмагц,

–Энэ бол ажил хэрэгч саналууд шиг санагдаж байна, хүлээн авч болно гэж бодож байна. Сергей Миронович, чи юу гэж бодож байна? гэж асуув.

–Надад татгалзах юм алга гэж Киров зурж байгаа юмнаасаа хараа салгалгүй өчив.

Сталин ширээн дээрээс тариа хураалтын мэдээг авч Кировт өгөв.

–Хараач!

Мэдээний дотор Казахстаныг улаан харандаагаар зурсан байв. Төлөвлөгөөний биелэлт далан хувьтай, бүхэлд нь авч үзвэл тэр нь дундаж үзүүлэлт ажээ.

–Мирзоян хоцорч байна, бидний болгоомжлоод байсан зөв болж таарлаа гэж Сталин хэлэв.

–Эднийх ч хамгийн муу нь биш л байна л даа, далан хувьтай байна... Гэхдээ шамдуулах хэрэгтэй нь мэдээж гэж Киров хариулав.

–Энэ дундаж хувины цаана зарим мужийн бүр нурчихсан ажил нуугдаж байгаа юм хэмээн Сталин ирж ширээн дээрээс бас нэг хуудас авч харснаа,

–Жишээ нь Дорнод Казахстаны муж бэлтгэлийн төлөвлөгөөг дөнгөж гучин наймхан хувиар биелүүлсэн байна. Зүгээр ч үгүй ургац маш сайн байхад тэр шүү. Гэтэл тэр маш сайн ургац нь бидний бодож байсанчлан тайвшрах, амарлингуй хандах байдал бий болгож, орон нутгийн удирдлага сандарч гүйцсэн байна. Казахстанас ирсэн мэдээлэлд тэнд машин техникийг муу ашиглаж байгаа, механикжуулагчдыг эсэргүүцэх уур амьсгал байгаа, улсын хөрөнгийг шамшигдуулах, үрэн таран хийх, газар зохион байгуулалтын аппаратад хөндлөнгийн гэмт этгээдүүд, намын батлах өвөртөлсөн луйварчид шургалах явдал байгаа тухай дурдсан байна. Байдлыг яаралтай засах хэрэгтэй, эс тэгвэл оройтно. Казахстан бэлтгэлийн төлөөвлөгөөг нураачихна, ялангуяа одоо бид талх нормчлохыг болиулах гэж байхад улс орны талх тарианы хүртээмжид маш муугаар нөлөөлж мэднэ. Хэн нэг хүнийг нөхөр Мирзоянд туслуулахаар явуулах нь зүйтэй гэж би бодож байна.

–Гомдчихгүй биз дээ? хэмээн Киров тээнэгэлзэж,

–Бид түүний хүчинд итгэхгүй байгаа гэсэн хэрэг болно. Харин зүгээр бичиг явуулж, ажилтан нараа шахаж шаард, хүн хүч, тээврийн хэрэгслээр тусалж болно гэвэл яасан юм бэ? гэв.

–Яалаа гэж гомдох билээ? гэж Сталин тамшаалаад,

–Намд гомдож болохгүй. Хэрвээ бид нар дор бүрдээ намд гомдоод эхлэх юм бол намаас маань юу үлдэх вэ? Мэдээж эв зүйг бодох хэрэгтэй л дээ, зааварлагч явуулахгүй, Төв Хорооны нарийн бичгийн дарга явуулья... Ингэхэд, Сергей Миронович, чи өөрөө түүн дээр очоод ирвэл яасан юм бэ? Та хоёр нөхөрсөг харилцаатай, бас нэмэрт нь Улс төрийн Товчооны гишүүн очно гэдэг чинь хүндтэй шүү дээ! гэв.

Киров байдал ингэж эргэнэ чинээ даанч бодсонгүй. Ленинградаас дор хаяхад бүтэн сар хөндийрч Казахстанд явна гэж... Гэтэл энд Сочид Сталин түүнийг есдүгээр сарын турш барьчихаж мэднэ. Гэхдээ Сталин түүнийг энд байлгахыг хүсэхгүй байна, тэр хоёрын харилцаа хүйтэрчихсэнийг хэлэх үү, нэг тийшээ салж явах шиг сайхан юм ёстой алга. Сталин түүнийг эндээс зайлуулахын тулд Казахстаныг ашиглаж байгаа юм биш биз? Ленинград руу зүгээр буцаачихвал тэр хоёр хамтарч ажиллаж чадаагүй, юу ч бүтээгүй гэсэн үг болно. Харин Казахстаныг яаралтай дээш нь татаж гаргана гэдэг бол тун аятайхан шалтаг, Киров, Мирзоян хоёр хувийн найзууд гэдгийг ч бодсон, бас өөр хэд хэдэн талаас нь бодоход Кировыг явуулах нь хамаагүй дээр. Ингэх юм бол түүний Сочигоос гэнэтхэн яваад өгсөн тухайд элдэв цуу яриа гарахгүй. Сталин Кировыг ийшээ ирсэн анхны өдөр л Казахстаны тухай яриа сэдэж

байсан нь гагцхүү жаахан сэжиг төрүүлнэ. Яагаад тэгсэн юм бол? Тэр хоёр гар нийлж ажиллаж чадахгүй гэдгийг урьдаас мэдээ юу? Түүнийг буцаах ажлаа эртнээс бэлтгэсэн хэрэг үү? Сталин хашир хүн юм чинь тэгсэн ч байж магадгүй. Ямар ч атугай ийм санал хэлсэн нь Кировг эндээс бушуухан явах боломж олгож байна. Мэдээж өөр шалтаг олбол олох л байсан, эсвэл зүгээр л Минводы хот руу явуулчих шүү дээ, тэгье гэвэл янз бүрийн шалтаг эрэхийн ч хэрэг байхгүй, эмч нар тэгэх шаардлагатай гэсэн гээд л гүйцээ. Гэвч мань хүн Енукизегийн тухай бичихээс татгалзчихсан, Москвад шилжиж ирэхээс татгалзчихсан, гурав дахь удаагаа татгалзвал тэр хоёрын харилцаа нэгмөсөн хурцдана.

–За яахав, хэрвээ шаардлага байгаа бол би явья гэж Киров хэлэв.

–Шаардлага байна, чи үүнийг өөрөө сайн ойлгож байгаа, бас тэгээд хэмээн Сталин түүхийн тэмдэглэлийн хуудаснууд руу зааж,

–Намайг харахад энэ ажил чиний сонирхлыг нэг их татахгүй байна, тийм биз дээ? гэв.

–Тэр ч тийм шүү, би ямар юмных нь түүхч байх вэ дээ... гэж Киров нотлон өчлөө.

–Тэгж таарна аа! Харин тэнд бол амьд ажил байгаа. Чи лав сараас илүү болохгүй, гэтэл Казахстанаа татаад гаргаад ирнэ, талх тариатай болно. Казахстаны юу нь төвөгтэй вэ? Нэгдүгээрт, төвөөс хол зах хязгаар нутаг. Хоёрдугаарт, эрээвэр хураавар, чухамдаа газар тариалан цоо шинээр эрхэлж байгаа хүмүүс. Хөрөнгөө хураалгасан нударганчууд тэнд олноороо суурьшсан. Тэдний дунд ажилч хичээнгүй сайн ажилчид бий гээд Сталин Жданов руу эргэж,

–Шинэ газар очоод гурав юм уу таван жил сайн ажилласан хуучин нударганчууд, ялангуяа залуучуудын эрхийг сэргээн тогтоох тухай зарлиг бэлтгэхийг би үүний өмнө хүсэлт болгосон юм. Андрей Александрович, танд төвөг болохгүй бол тэр тухай шалгачихаарай... Нээрэн, тэдний дунд ажилсаг хүмүүс ч бий, гэхдээ өширхсөн хүн ч бас олон бий, тэд нар бидэнд хор хүргэж байгаа юм. Нөгөө талаас бид манай хүмүүст, жирийн ажилтан нарт, жирийн хөдөлмөрчдөд хөдөлмөрийн наад захын хүмүүжил олгоогүй, эрхэлсэн ажлаа аль болохоор сайн хийх хүсэл эрмэлзэл бий болгоогүй, тэдэнд хийсэн ажлынхаа чанар, өөрийнхөө мэргэжил, ажилчин хүнийхээ нэр алдраар бахархах үзлийг хөгжүүлж төлөвшүүлээгүй байна. Сая Москвагаас над дээр нэг шүдний эмч ирж миний шүдийг эмнэхдээ өөрийнхөө бодсоныг санал болгоход нь би татгалзсан юм. Түүнийг өөрийнхөөрөө зүтгэж эхлэхэд би биеэ барьж чадалгүй дуугаа чангалахад хүрсэн юм... Гэхдээ сонин юм нь юу вэ? гэхлээр мань хүн миний хэлсэн, өөрийнхөө хэлсэн хоёрыг аль алиныг нь хийчихээд надад хоёуланг нь хийж үз гэж өглөө. Эхлээд минийхийг, дараа нь өөрийнхийгөө. Би хийгээд үзсэн чинь түүний хэлдэг дээр болж таарсан, тэр тухай би өөрийгөө шүүмжлэх журмаар буруугаа хүлээсэн. Тийнхүү тэр эмч өөрийнхөө зөвийг нотолж, өөрийнхөөрөө санаснаар болгож чадсан. Юуны төлөө тэр вэ? Миний хүссэнээр хэл амгүй хийчихээд хэл амгүй яваад өгч болох л байсан. Гэтэл тэгээгүй, өөрийнхөөрөө болгосон, өөрийнхөөрөө болгох гэж зүтгэхээс айгаагүй, миний шууд хоригийг зөрчихөөс айгаагүй. Яагаад айсангүй вэ? Мэргэжлийнх нь нэр төр дийлсэн хэрэг. Тэгэхлээр энэ бол жинхэнэ ажилтан хүн, түүний мэргэжлээрээ бахархах үзэл гарамгай хөгжсөн байна, бид манай хүмүүст чухамхүү ийм үзлийг төлөвшүүлж бий болгох ёстой. Тэгээд бид ийм үзлийг төлөвшүүлж чадсан цагт албадсан арга хэрэглэх шаардлага арилна. Гэвч одоохондоо

энэ бол байхгүй байна, бид одоохондоо ажил үйлсдээ чин үнэнч байх тухай ихээхэн бурж, тангараг тавьж, үүрэг амлалт авч байна, гэтэл үүрэг амлалт бол гүржийн дарс исгэгчдийнх шиг эсвэл саяын тэр шүдний эмчийнх шиг ажилчин хүний сэтгэлийн дуудлага, ажилчин хүний мэргэжлийн бахархлаар төрсөн ганцхан зүйл байх ёстой гэв.

–Тэр эмч чинь аятайхан хүн байдаг шүү хэмээн Киров инээмсэглэв.

Сталин зогтусав.

–Тэр чинь чамайг эмчилж байсан юм гэж үү?

–Үгүй ээ, бид хоёр нарлах талбай дээр таарсан юм. Сайхан сэлдэг хүн байна лээ!

Сталин өрөөн дундуураа чимээгүй хэд алхалснаа,

–Тэгвэл чи чинь энд ер уйдаагүй байх нь ээ, би гэдэг хүн манай Сергей Миронович энэ хэдэн тэмдэглэлтэй бүр уйдаж гүйцлээ гэж бодож байсан юм гэв.

Сталины дуунд Кировын сайн мэдэх хардаж сэрдсэн аяс илэрснийг тэрээр анзаарав.

–Нарлах талбай хоосон, эмч бид хоёроос өөр усанд орох хүн огт байгаагүй. Ер нь би түүнийг хоёр удаа харсан, надад аятайхан хүн шиг санагдсан шүү.

–Тийм ээ, яриа хүн гэж Сталин хайхрамжгүйхэн өгүүлэв.

Энэ хайхрамжгүй янз Кировт бас сайн танил зүйл. Сталин дахиад өрөөн дундуураа үг дуугүй хэд алхалж Кировын дэргэд ирж зогсоод,

–Маргааш Алма-Ата руу нисэж чадах уу? гэж асуув.

–Чадалгүй яхав.

–За тэгвэл сайн байна.

Сталин орой нь элдэв бичигт гарын үсэг зурж байхдаа,

–Шүдний эмч Липманыг өөр хүнээр соль гэж Товстухад хэлэв.

Тэгээд бодолхийлснээ,

–Түүнийг Кремлийн эмнэлгээс хал, гэхдээ оролдож болохгүй гэж нэмж өгүүлэв.

Алфёров түрүүчийнх шигээ энгийн хувцастай байх агаад түрүүчийн нэгэн адил Сашаг зочныхоо өрөөнд хүлээн авч, хоолны ширээ рүү сандал дөхүүлж тавив. Ширээ нь банзаар зааж хийсэн ердийн ширээ, харин сандал нь зөөлөн суудалтай хот маягийн сандал,

–Панкратов, суу, цай уух уу?

Иймэрхүү нахилзах олигтой юм болохын дохио биш.

–Баярлалаа, би өглөөнийхөө ундыг уучихсан.

–Аяга цай юу нь илүүдэх билээ, та чинь явуулын хүн шүү дээ. Юугаар ирэв?

–Явган ирлээ.

–Тэгэх тусмаа...

Алфёров гал тогооны хаалгыг нээв.

–Анфиса Степановна, бидэнд цайны халуун тогоо тавьчихгүй юу.

Ширээ рүү буцаж ирээд Саша руу нөхөрсөгөөр харлаа.

–За Панкратов, юутай вэ, сүүний машин ажиллаж байгаа юу?

–Мэдэхгүй, би сонирхохоо больсон.

–Тусгүй л байна даа. Тэгвэл тэр чинь ажиллаж байгаа. Надад баярлалаа гэж хэлбэл таарна... Би МТС-ыг заавал засаарай гэж гуйсан юм. Яг тэр өдөр нь засчихсан.

Тэгэхлээр Зида үнэн хэлсэн байх нь. Алфёров Саша руу хяламхийв.

–Би бодь сэтгэл гаргасандаа тэгсэн юм биш гэдгийг та ойлгож байгаа. Манай харьяаны хүн машин эвдсэн бол бид түүнийг нь засах үүрэгтэй учраас л тэгсэн юм.

–Танай ”харьяаны” хүн машин эвдлээгүй.

–Тосгоныхон энэ тухай өөр бодолтой байгаа. Ямар ч байлаа гэсэн сүүний машин засагдсан, тэр явдал дууссан. Гэвч дууссан гэхээсээ жаахан дарагдсан гэж хэлэх нь оновчтой байх. Таны талаар бичсэн өргөдөл надад байж л байгаа гээд Алфёров ширээнийхээ нүд рүү зааснаа,

–Тэр өргөдлөөр таныг сүрдүүлэх бодол надад байхгүй, гэхдээ тэр тухай хамтралын дарга нэхэн санаж мэдэх юм. За тэр ч яахав, бид энэ асуудлыг эргэж ярих цаг ирнэ. Цай бэлэн болчихлоо! гэв.

Урт банзалтай, богинохон цамцтай дунд хэрийн насны биерхүү халбаганасан авгай халуун

тогоо оруулж ирээд тавагтай аньс, өндөгтэй хайрсан загас, мөнхүү загас, аньс, хар нэрсний хуушуур энэ тэрийг ширээн дээр тавив.

Алфёров цайныхаа идээг хийх зуур,

–Цайг би өөрөө хандалдаг юм. Тун нарийн ажил шүү дээ, би Хятадад байхдаа сурсан юм гэв.

Тэрээр гүцээ халуун тогооны жалавчин дээр тавиад хэд давхарлаж нугалсан алчуураар бүтээв.

–Цай идээших зуур юм идэж бай гээд Алфёров ширээн дээрхийг тойруулан дохив.

–Баярлалаа, цай л ууя, өглөө юм идсэн, одоо идмээргүй байна.

–За яах л санж вэ, харин идмээр болбол идээрэй, явцын дунд дур ордог шүү дээ. Мозговад ямар байна, уйдаж байна уу?

–Хөгжих юм ч ховор шүү.

–Яаж бал бурамтай адилтгах вэ хэмээн Алфёров санаа нийлж,

–Гэхдээ танай тэнд нэлээн сонин хүмүүс бий. Всеволод Сергеевич Жилинский философич хүн, Бердяевын шавь. Тухайн үедээ гадаадад явчихвал болох л байсан гэвч Оросыг хайрлах сэтгэлээсээ болоод татгалзсан гэж байгаа. Одоо бол мэдээж явчихмаар л байгаа л даа, даанч хожимдчихож. Нээрэн л Орост хайртай юм бол түүний эсрэг биш түүний төлөө ажиллавал зохино. Тийм биз дээ? гэв.

Саша дал мөрөө хавчив.

–Зарчмын хувьд тийм л дээ, гэхдээ Оросын эсрэг түүний юу хийснийг би мэдэхгүй юм.

–Жилинский ч гэсэн, бусад нь ч гэсэн цөмөөрөө энд хилсээр ирсэн гэж танд итгүүлэх гэж оролдоно. Гэхдээ энд хилсээр ирдэг хүн гэж огт байхгүй гэдэгт та итгэж болно.

Саша жуумалзав.

Алфёров түүнийг нь анзаарчихлаа.

–Та өөрийгөө хэлэх гэж байх шиг байна, харин та бол огт жич хэрэг. Таныг цөлсөн явдал бол манай намын дотоод хэрэг, Пушкины хэлсэнчлэн “Ах дүүсийн эртний маргаан...” Та тодорхой нэгэн нөхцөл байдалд орчихоод түүнээсээ болж дэндүү болгоомжгүй байна. Энэ нүх рүү намайг сайн дураараа ирсэн гэж бодож байна уу? Та Богучанын бүрэн эрхт төлөөлөгчийг хараа биз дээ? Энд бол тиймэрхүү хүн байхад л болох юм. Би бол арай өөр хүн гэдгийг таныг ойлгож байгаа болов уу гэж найдаж байна. Гэхдээ би ч гэсэн хүн хэлэлтгүй өөртөө тохиолдсон байдлыг олигтой ухаараагүй учраас энд ирчихээд байгаа юм. Тэгсэн ч гэсэн яах вэ дээ? Би коммунист хүн, тэгээд л өөрийнхөө үүргийг гүйцэтгэж байна. Тэгэхлээр нөгөө Жилинскийн тухайд... Ухаантай, эрдэмтэй хүн, гэхдээ түүнтэй тун болгоомжтой байх

хэрэгтэй шүү.

–Би түүнтэй зүс мэдэх төдий танил, ер нь бараг нийлдэггүй шүү.

–Та хүсэвч, эс хүсэвч түүнтэй нийлэх л болно хэмээн Алфёров зөрж,

–Гурван жил жимийлцэж тоглохгүй нь лав, нийлж л таарна. Танай тэнд бас Михаил Михайлович Маслов байгаа, Жанжин штабын хурандаа явсан хүн гэв.

Саша Алфёровын ямар зорилготой байгааг таамаглаад авах шиг санагдаж,

–Миний ёстой сонирхдоггүй хүн чинь тэр дээ гэв.

–Тэгэлгүй яахав хэмээн Алфёров тосгон авч,

–Уе мултарсан, өөр бүтцийн хүн. Таны замд цуг таарсан улс чинь үгүйдээ насаар ойролцоо. Квачазег л аваад үз л дээ... Та хоёр захидлаар харилцаж байна уу? гэв.

–Үгүй ээ, хаана байгааг нь ч мэдэхгүй.

–Та чинь яагаад замынхаа нөхдийг ингээд хаячихсан юм бэ? гэж Алфёров сониучирхсанаа,

–Үгүй ээ, би таныг ч ойлгож л байна. Квачазе бол троцкист, зүгээр ч үгүй бүр архаг троцкист. Харин нөгөө Соловейчик... гэв.

–Соловейчик бид хоёр хаа нэг бичилцэж байгаа. Тэрээр энэ тухай ярихгүй байвал болох л байсан.

Та намайг яах гэж дуудсан юм бэ? Байцаах гэж дуудаа юу? Тэгвэл яг номоор нь мөрдөн байцаа л даа, надад бол иймэрхүү яриа сонин биш байна гэж хэлбэл хэлэх л байсан. Гэвч Саша ингэж хэлсэнгүй. Алфёров өөрт нь ямар ч муу юм хийгээгүй, хүний ёсоор л юм ярилцах гэж байна, тэр бололгүй яахав, тийм байдлаар ярилцаж болох байна.

–Түүний сүүлчийн захиаг аваад удаж байна уу?

–Та мэдэхгүй гэж үү? Миний бүх захидал харилцааг та мэдэж байх шиг надад санагддаг юм гэж Саша хариулав.

–Тийм ээ, захиргааны цөллөгийнхний шууданг заримдаа шалгах хэрэг гардаг юм, бидэнд тийм үүрэг бий гэж Алфёров түүний хэлснийг батлан өгүүлээд,

–Гэхдээ би байнга үздэггүй, хаа нэг сонгож үздэг юм гэв.

–Миний захиа дандаа л онгорхой ирдэг юм.

–Буцааж наах нь учир утгагүй юм хэмээн Алфёров инээд алдаж,

–Захидлыг чинь нээснийг та тэртэй тэргүй мэднэ шүү дээ. Гэхдээ дахин хэлэхэд би хаа нэг сонгож үздэг, тийм учраас Соловейчикийн сүүлчийн захидлыг хараагүй байж магадгүй гэв.

–Түүнд ямар нэг юм тохиолдоо юу? гэж Саша асуув.

–Гойдын юм болоогүй. Гольत्याвинод шилжүүлж өгөөч гэж гуйгаад байгаа юм, тэнд сүйт бүсгүй нь байдаг юм гэнэ. Тэр үнэн үү?

–Үнэн, сүйт бүсгүй нь тэнд байдаг юм. Бид Гольत्याвиног дайрч өнгөрөхөд би тэр хүүхнийг нүдээрээ харсан гэж Саша өгүүлэв.

–Гольत्याвинод түүний сүйт бүсгүй байж болох л доо. Гэхдээ энэ бол заагдсан нутгаа дураараа хаяж яваад байх эрх түүнд олгохгүй. Гэтэл тэр нөхөр Гольत्याвино руу зөвшөөрөлгүй явсан байна. Би энэ хэргийг залуу хүний явдал, хайр сэтгэл гэх мэтээр бодоод нэг их тоохгүй байсан байж магадгүй. Гэтэл Гольत्याвино бол Дворецийн комендантын харьяа газар, тэндхийнхэн үүнийг тоохгүй байж болохгүй гэж үзэж байгаа юм.

–Би тэр тухай огт мэдээгүй шүү гэж Саша өгүүлээд,

–Гэхдээ түүнийг ойлгож болох юм. Ийшээ цөллөгт хэн нэгэн хүн тохиолдлоор ирсэн байдаг юм гэж санавал улс төрд ямар ч холбогдолгүй Соловейчик л чухамхүү тийм хүн байгаа юм. Нэмэрт нь тэр бол хүнтэй нийцтэй, цайлган сэтгэлтэй, ийм хашилт шахалтад ёстой зовж байгаа хүн. Тэгж дураараа загнасан нь мэдээж хачин хэрэг байна, гэхдээ хайр сэтгэлд хориг саад гэж байх биш дээ гэв.

–Панкратов оо, чи дэндүү нялуун юм ярьж байна, түүний тэр явдлыг албаны хэлээр бол оргох гэдэг юм! Тэгээд оргосны төлөө оргодлыг төдийгүй оргоход дөхөм үзүүлсэн хүмүүсийг бас шийтгэнэ. Рожковод түүнээс өөр цөллөгийнхөн бас бий, гэтэл тэднийгээ давхар хөөдчихсөн байна.

–Мозговаас хэн нэг хүн оргочихвол би бас хариуцах болох нь уу?

–Тийм, нэг нь орголоо гэхэд бусад нь бүгдээрээ хариуцна гэж мэд. Тэгэхлээр хувиа бодож хар амиа хоохойлогчдоос гэмгүй хүмүүсийг хамгаалж байх хэрэгтэй. Оргохоор зэхэж байгаа аливаа оролдлогын тухай засаг захиргаанд мэдэгдэх хэрэгтэй, журам тийм юм. Энэ талаар бидэнд туслах хэрэгтэй. Та жишээ нь өөрийгөө зөвлөлтийн шулуун шударга хүн гэж нотолж байна. Бидэнд тусал л даа!

–Өө, та чинь намайг ийм хүн болгох гэсэн юм уу?

–Александр Павлович, тэгж ярихын хэрэг юу байна? Далдуур туршуул хийхэд хатуу шийтгэлтэй шүү. Хүмүүсийн юу бодож байгаа, юу ярьж байгааг мэдээлж байхыг бид гуйж байгаа юм биш. Бид бол оргохоос урьдчилан сэргийлж, оргож байгаа хөнгөмсөг хүмүүс, тус дөхөм үзүүлж байгаа итгэмхий хүмүүсийг л аврах гэсэн юм. Таныг МТС-ын явуулын механикчаар Кежма руу шилжүүлэв. Тэгээд районоор чөлөөтэй явж цөллөгийнхөнтэй уулзаж учрах болно, оргох санаатай хүмүүстэй ч бас тааралдах болно. Та тийм хүмүүст ятгалга хийх

юм. Арга барсан цагт биднээр урьдчилан сэргийлүүлэхийн тулд манайд мэдэгдэж байх болно. Материаллаг талаасаа дутах гуцах юмгүй болж, тосгонд суухын оронд районы төвд сууна, тэгээд хүмүүсийг болчимгүй явдлаас аварч байх болно.

–Та цагаа дэмий үрж байна. Таны хүсэж байгаа ажлыг би хийхгүй. Ёс суртахуунд харш явдал гэж үзэж байна гэж Саша хэлэв.

–Миний ажлыг та бас ёс суртахуунд харш гэж үзэж байна уу?

–Та алба хааж, албан үүргээ гүйцэтгэж байгаа хүн. Би бол цөллөгийн хүн, бас өөрийнхөө үүргийг л биелүүлнэ.

–Ямар үүрэг?

–Хугацаагаа дуусгах.

Алфёров дуугүй азнаснаа инээмсэглэж,

–Александр Павлович, та намайг тун бэрх байдалд оруулж байна гэв.

–Би таныг ойлгохгүй байна.

–Та “хайр сэтгэлд хориг саад гэж байхгүй” гэж хэлсэн, таны зөв, тэгж саная. Гэтэл таны авгай багш. Улс төрийн хувьд түвшин бус хүний авгайд өсвөр үеийг хүмүүжүүлэх ажлыг бид итгэн хүлээлгэж болох уу?

–Надад авгай байхгүй, та юу ярьж байна? Багш ий? Би хааяа нэг тэднийд ном авах гэж орж гардаг, тэрнээс цаашгүй дээ.

–Александр Павлович, та бид хоёр чинь эр улс, бие биеэ сайн ойлгож байна. Таныг ингэж л хариулна гэж бодож байсан юм. Гэхдээ багш хүүхэн бол таны авгай. Тэгэхлээр та ухаалаг хандах юм бол бид таныг төдийгүй тэр хүүхнийг ч гэсэн Кежмад шилжүүлнэ, тэнд ч бас багш хэрэгтэй юм чинь.

–Надад ямар ч авгай байхгүй хэмээн Саша хөмсөг зангидаж,

–Ингэж ярих юм бол та Мозговын аль ч хүүхнийг миний авгай болгочихож чадах юм байна. Хэрвээ та тэр багш эмэгтэйд халдах юм бол маш шударга бус хэрэг үйлдэнэ гэсэн үг гэв.

–Түүнд халдах гэсэн хүн алга. Гэхдээ бид түүнийг элдэв муу нөлөөнөөс хамгаалах ёстой. Жишээлбэл таныг өөр газар шилжүүлэх замаар,

–Та нар эзэд юм чинь! хэмээн Саша бие нь тавирч шүүрс алдав. Яах л санж вэ! Өөрөө өөр тосгонд л очно биз, гагцхүү Зидаг л зовоохгүй байвал барж.

Алфёров босож тасалгаан дундуур хэд алхав...

–Панкратов, та амьдралынхаа замыг хэрхэн төсөөлж байгаагаа хэлэхгүй юу?

–Цөллөгийн дараа гэртээ харьж, өөрийнхөө хэргийг дахин хянуулахаар хөөцөлдөнө.

–Та Москвад буцаж очихгүй, тийм зөвшөөрөл өгөхгүй.

–Ажил хийж болдог газар ганц Москва биш.

–Хэргээ дахин хянуулна гэнэ ээ? Та тэгүүлж бараг чадахгүй биз дээ. Ял эдэлсэн нэр зүүлтгүй л байх болно.

–Ялыг арилгадаг явдал бий шүү.

–Бий гэж Алфёров толгой дохиод,

–Гэхдээ улсад гавьяа байгуулбал тэгдэг юм. Гэтэл танд ямар нэг ер бусын үйл бүтээх эрмэлзэл харагдахгүй байна. Та чинь төрд гомдсон хүн шүү дээ гэв.

–Би төрд гомдсон хүн биш. Гэхдээ намайг бариад явахад ээж маань үүдэндээ яаж тарчилсныг би мартажгүй. Бас мөрдөн байцаагч над яаж хэрэг өмсгөснийг би мартажгүй.

–За тийм байж хэмээгээд Алфёров дахин түүний өөдөөс суух зуур,

–Ажилдаа оръё. Соловейчик оргочихсон байна! гэв.

Тэрээр Сашаг сонжин харав. Саша мэл гайхаж цэл хөхөрсөн янзтай түүн рүү харлаа.

–Тийм байх ёсгүй. Соловейчик тийм тэнэг хүн биш, оргоод хаашаа ч явах газар байхгүй гэдгийг сайн ойлгож байгаа.

–Ямар ч л гэсэн оргочихсон байна, танд ямар нэгэн юм бичиж байсан уу?

Саша мушилзав.

–Оргоно гэдэг тэнэг хэрэг, тэр тухай бичвэл бүр ч мунхаг явдал болно.

–Тэр яг тийм гэж Алфёров толгой дохиод,

–Ямар ч атугай та энд түүний цорын ганц найз, цорын ганц нөхөр нь шүү дээ гэв.

–Та надад хамсаж оргуулсан хэрэг тулгах гэж байна уу?

–Панкратов, би танд таны бодож байгаагаас хавьгүй илүү сайн байгаа хэмээн Алфёров нухацтай өгүүлж,

–Танд тийм ял тулгасан хүн огт алга. Гэвч Соловейчик оргох замаа сайтар бодсон байгаа. Тийм зам хоёр бий. Нэг нь Ангара уруудаад Енисей хүрэх, нөгөө нь тайгаар явж Канск орох. Аль ч замаар нь явсан тэр холдож чадахгүй, анхны таарсан гацаанд л түүнийг бариад авна.

Суурин газрыг тойрч явна гэвэл хүнсний ихээхэн нөөц хэрэгтэй, түүнд тийм нөөц байхгүй. Гэтэл бас Ангара өгсөөд Эрхүү хүрэх гурав дахь зам байж болно. Энэ зам нөгөө хоёроосоо тавиу, гэхдээ мөрт нь таны сууж байгаа Мозгова байна, тэгээд түүнээс дээш сүйт хүүхнийх нь талынхан байдаг хоёр суурин бий. Чухамхүү энэ замыг сонгож авсан гэхэд үгүй гэхийн газар байхгүй, тэгэхлээр тан дээр хүрээд ирнэ гэхэд бас үгүй гэхийн газаргүй.

–Тэр чинь над дээр яаж ирэх болж байна? Хамаг тосгоныхны нүүрэн дээр үү?

–Би үүнийг мэдэхгүй. Ирэхгүй ч байж магадгүй. Гэхдээ ирж ч магадгүй. Тэгвэл та хэрхэхээ сайн бодох нь зүйтэй.

–Түүнийг бариад авах уу? хэмээн Саша инээд алдаж,

–Хэрвээ би дийлэхгүй бол яах вэ? гэв.

–Барихын хэрэггүй, бид өөрснөө бариад авна. Ятгаж байгаад буцаачихвал л сайн юмсан. Тэгэх юм бол оргосон гэж яллах шаардлагагүй болж, зүгээр л дур мэдэн тэнэсэн гэдгээр захиргааны арга хэмжээ аваад өнгөрөөж болно. Панкратов оо, би үнэн хэлж байна шүү, оргосон хэрэг битгий гараасай гэж би хүсэж байгаа юм, надад элдэв онцгой явдал хэрэг байхгүй.

Алфёров чин санаанаасаа ярьж байгааг Саша мэдэв. Гэхдээ тэрээр Соловейчикийн оргосон гэдэгт итгэхгүй байв. Тайгад анчилж яваад төөрчихсөн байж магадгүй шүү дээ.

–За ийм байна, Панкратов. Та түүнийг ятгаад буцаачихаарай, хамгийн хялбар юм тэр. Харин буцаж өгөхгүй бол тосгоны зөвлөлд юм уу хамтралын захиргаанд хэлчихээрэй, тэд хэрхэхээ мэднэ хэмээн Алфёров яриаг төгсгөв.

Тэгээд хэсэг зуур чимээгүй байснаа,

–Панкратов, та үүнд мөчид хандаж болохгүй шүү, оргодлыг нуун хаацайлах буюу түүнд тус хүргэвэл өөртөө ноцтой уршиг тарих вий. Урьдчилсан анхааруулга авлаа гэж үзээрэй! хэмээн нэмж өгүүлэв.

Соловейчик оргочихлоо гэнэ ээ? Саша үүнийг үнэмшиж чадсангүй. Харин амьдрал нь нэгэнт баларлаа гээд боож буюу живж үхсэн байж болохоор бодогдоно. Саша өөрөө амиа хорлох дээрээ тулж байгаагүй гэх үү? Харин оргоно гэж юу гэсэн үг вэ? Соловейчик хэрсүү олон зангүй хүн юм чинь оргоход ямар ч утга учиргүй гэдгийг гарцаагүй ойлгоно. Тэгэхдээ хүрсэн бол Канскаас явчихаа мэдэлгүй яахав дээ, тэндээс бол галт тэргэнд суугаад л болох нь тэр. Энд байхад Фридатай нийлнэ гэж найдаад байж болох байсан, оргосноор тэр найдлагаа бүрмөсөн үгүй хийнэ гэсэн үг. Нэмэрт нь Фридаг бөөн хэрэгт хийчихнэ. Мань хүн бол түүнд ямар ч байсан гай тарихгүй баймаар юм.

Алфёров ямар урхи тавих гээд байна вэ? Чиний нөхөр цөллөгөөс оргосон, чи хариуцлагыг нь хүлээх хэрэг гарах вий, тийм учраас бидний ард нуугдчих! Багш хүүхэнтэй толгой холбосон байна, тэр чинь үүнээс болж зовж мэднэ, тэгэхлээр бас л бидний ард нуугдчих! Мозгонад чи

ажилгүй байна, хэн чамайг гурван жил тэжээх юм бэ? Харин би бол чамд ажил өгнө, чи ар гэрийнхнийгээ зовоох хэрэггүй болно. Түүнээс гадна сүүний машины хэрэг чам дээр хэвээрээ байгаа, бичиг нь энэ ширээнд байна. Иймэрхүү санаа байна гэхэд даанч болхи юм даа.

Саша ингэж бодохын сацуу Алфёров хүнээс өөр, нэг л ер бусын юм шиг санагдана. Дьяковтой жиших юм алга, түүний дэргэд шал өөр шонхор, Хятадад сууж байсан гэж байгаа, Дьяковыг бол яаж Хятад руу зүглүүлэх вэ дээ. Гэтэл Дьяков Москвад төв аппаратад байгаа, мань Алфёров энд, энэ бөглүү газар байж байна. Баалуулсан байх аа даа чи. Харц нь болгоомжилсон янзтай байгаа нь түүний суурь хэврэгхэн буйн шинж. Бас Дьяков шиг муйхарлаж зүтгэхгүй байх юм. Нэг их хичээхгүй байгаа юм болов уу?..

Саша Всеволод Сергеевичид Зидагаас болж дуудсан байна гэж хэлжээ. Оргосон гэж итгэхгүй байсан учир тэр тухай ярьсангүй.

Всеволод Сергеевич түүний ярьсныг тайван сонсов.

–Их л сайндаа Савинод юм уу, эсвэл Фроловод шилжүүлнэ биз. Хоёр сар жаргасны төлөө тэр хэрийн үнэ төлөхөд юу шалих вэ. Харин Нурзида Газизовнаг бол ер яах ч үгүй, тэр чинь энд Алфёровоос илүү үнэтэй цэнэтэй хүн. Энд ирэх өөр бүрэн эрхт төлөөлөгч олдоно, өөр багш бол олдохгүй.

Саша Соловейчикийн тухай Зидад ярьжээ. Тэгээд өөр шигээ бас итгэхгүй байх гэж санасан чинь Зида итгэхийн цаагуур итгэв. Тэрээр,

–Уйтгар гунигтаа авгаад л оргочихдог юм. Маш хэрсүү хүн ч оргоно. Байж суух ухаанаа олохоо больчихоод л оргочихож байгаа юм. Энэ бол ердийн зүйл гэж хэлжээ.

Саша Алфёровтой ярилцсаны дараа сэтгэлийн зовлонгоосоо ангижирч бүх санаа амарсныг гайхалтай хэрэг гэмээр. Гэвч Москваг дахиад харахгүй, хэргээ дахин хянуулах найдлага байхгүй гэж өөрийнх нь бодож байсныг Алфёров нотолсон учраас тэгжээ. Түүнийг данснаас гаргасан хэрэг. Одоо ааяа гэх вэ, өөрөө ч гэсэн өөрчлөгдөх ёстой болох нь. Тэрээр эцсийн бүлэгт ийнхүү хувь тавилантайгаа эвлэрч, өөрийгөө захирч чаддагаа мэдрэв. Элдвээр горьдохын хэрэг алга. Түүний хэрэгт онцгой юм ер байхгүй, түүн шиг хүн шороон түм байна. Тэгэхлээр тэсэж байгаад гарах хүчийг өөрөөсөө олох хэрэгтэй.

Тэрээр нэг удаа Тимофейтэй гудамжинд тааралдав. Цаадах нь түүн рүү хулмаганан харснаа зөрөөд явчих гэсэн боловч Саша зам хөндлөсөн таглав.

–Тимофей, чи яасан муу бууддаг юм бэ, эсвэл тийм хариугүй буутай юм уу?

–Чи чинь яачихаав? хэмээн Тимофей ухартусав. Нөгөө голын зүлгэн дээр зодсон шигээ бас цохиод авах вий гэж айсан юм байлгүй.

–Чи бүү ай, энд чамд заяа нь гар хүрэхгүй, харин дахиад ойд тааралдах юм бол гөлөг шиг нам буудна шүү. Чи бол зормол тугалгатай, би бол жинхэнэ сумтай, хурдан буутай, чамайг

гүйцэхдээ л нэг гүйцнэ. Би гүйцэхгүй юм гэхэд өөр хүн гүйцнэ. Бид өөрийн гэсэн шийтгэх аргатай шүү. Тогтоож аваарай, үхээр минь!

Саша тэгж хэлчихээд цаашаа яваад өгөв. Иймэрхүү хүмүүстэй ингэж л харьцах хэрэгтэй. Канскийн замд цөллөгийнхнийг алсан залуусыг шоронд цээрлүүлснийг Ангарынхан тэр аяараа мэдэж байгаа. Тимофей ч бас мэднэ. Муу хулчгар, одоо хоншоор чинь дутах вий! Саша ой руу явахдаа буугаа үрлэн сумаар цэнэглэхийн хамт зормол тугалга өвөртөлж явдаг болов. Зүгээр ч үгүй хэд хэдийг шүү. Бас Жучокгүй явахаа больжээ. Ил цулгуй газар зогсохоо бас больжээ. Явах зөргөө бас тухай бүр солих болжээ.

Тимофeyтэй тэгж ярилцсанаас хойш хоёр юм уу гурав хоногийн дараа Саша дахиад ой руу явжээ. Жучок нэг юмны үнэр авч гэнэт зогтуссанаа өтгөн ой рүү хар эрчээрээ харайлган оров. Борлон хуцах дуу нь энүүхэнд гараад байв. Тогтуухан чимээ өгч хуцаж байгаа биш, архирч багтран борлож байгааг бодоход хүн юм уу, аягүй бол баавгай руу хуцаж байгаа бололтой. Саша модны араар нуугдаж, бууныхаа сумыг аваад зормол тугалгаа хоёр гол руу сүмбэдэн шаав.

Жучок нэгэн амьтан руу нэг дайрч, нэг зайлж байгаа бололтой дуу нь холдож ойртон жигтэйхэн чанга улам боорлон хуцна. Энэ бол мэдээж Тимофей биш, Жучок тосгоныхныг бүгдийг нь таних юм чинь зөвхөн танихгүй хүнд юм уу, баавгайд л ингэж хуцаж таарна.

Сашад модны цаагуур хүн үзэгдэх шиг, юм хөдлөх шиг санагдав. Магадгүй салхи сэвэлсэн буюу мөчир хугарсан ч байж мэднэ... Жучок нэг цоорхойд ухасхийн гарч ирээд танихгүй хүн рүү дайрч, цаадах нь урт саваагаар нохойг хөөж байв. Саша тэр дороо түүнийг танилаа. Соловейчик аргагүй мөн. Хөвөнтэй өмд цамцтай, үстэй малгайтай, намгийн савхин гуталтай, хууз сахалтай туранхай эр. Танихад амаргүй байсан боловч биеийнх нь төрх, нохойг хөөж байгаа байдлаар нь Саша түүнийг таньжээ. Магадгүй Борис үнэхээр оргочихсон, Алфёровын чухамхүү энэ зүгт оргосон гээд буй таамаг зүйтэй гэж дотроо бодож байсан учраас ч тэгж таньсан байж болох юм.

Саша нохойгоо зандраад Соловейчик руу очив.

Тэр хоёр тэврэлдлээ. Саша,

–Буцаад ой руугаа орцгооё гэв.

Төглийн гүн рүү орцгоож эрхбиш сэврүүн гэхээр нэг модны ёроолд сууцгаав. Соловейчик үүргэвчээ мулталж хажуудаа тавиад толгойгоороо мод түшиж нүдээ анив.

–Чиний энэ чинь айхтар зуудаг нохой байна.

–Танихгүй хүн үзээд тэр... Юм идмээр байна уу?

–Одоохондоо үгүй, юм идсэн хэмээн үүргэвч рүүгээ дохиод,

–Чи чинь миний тухай хэдийн мэдчихээ юу? гэв.

–Намайг Алфёров дуудаж чиний тухай асуусан юм.

Борис нүдээ аниад хажуулдан хэвтэнэ.

–Чи яах гэж ингэв ээ? гэж Саша асуув. Соловейчик цэр нь ховхорч өгөхгүй зөндөө удаан хөхүүлэн ханиалгав.

–Намайг Фрида руу шилжүүлж өгөөч, эсвэл түүнийг над руу шилжүүлээч гэж би хичнээн гуйв? Тэгсэн чинь зөвшөөрдөггүй ээ. Би түүн рүү очих гээд явж өглөө. Замд бариад авах нь тэр. Тэгэхээр нь оргочихсон. Рожковод буцаж очих гэж үү? Оргосон хэрэг тулгаад шоронд хийчихнэ. Тэгээд л энэ зүгт гарсан юм. Намайг гол уруудаж юм уу, Канскийн замаар хайна, би тэр хооронд нь Братск амжаад орчихож магадгүй.

–Алфёров чамайг энэ зүгт явах байх гэж таамаглаж байна билээ.

–Чамд тэгж хэлсэн үү?

–Тийм.

Борис чимээгүй болов.

–Братск ороход бүтэн сар явах зам байна. Өнөө маргаашгүй өвөл болчихно. Ой дотор хөлдчихнө шүү дээ гэж Саша өгүүлэв.

–Надад өөр арга алга хэмээн Борис ядруу хариулаад,

–Хүрвэл хүрлээ л биз, хүрэхгүй бол тэр л биз гэв.

–Фрида юу болох вэ?

–Фридаг яах ч үгүй. Тэр маань юу ч мэдэхгүй байгаа. Би заагдсан газраа суурьшсанаас хойш түүний барааг хараагүй. Захидлаар харилцсан уу гэж үү? Би олон хүнтэй харилцаж байсан.

–Энэ ч яг тийм биш шүү хэмээн Саша зөрж,

–Чи түүнийг сүйт бүсгүйгээ гээд зарлачихсан, тэгэхлээр тэр чинь чиний дотнын хүн, түүнийг дуудаж байцаах нь лав гэв.

–Чамайг бас л дуудсан байна, чи юу хэлж өгөв дөө? Тэр ч гэсэн бас юу ч хэлж өгч чадахгүй.

–Хүүш, чи Кежма руу Алфёров дээр очвол дээр байх юм биш үү? Өөрийгөө Фрида руу шилжүүлэх юм уу, эсвэл түүнийг өөр лүүгээ шилжүүлж өгөхийг гуйхаар ирж явсан юм гээд түүнд хэлчихгүй юу. Тэгвэл байдал шал өөр болно, чи районоос хаашаа ч гараагүй, Кежмад өөрөө биечлэн ирсэн хэрэг болох юм.

–“Кежма руу ирж явсан” гэхэд худлаа гэдэг нь дэндүү илэрхий юм даа хэмээн Борис духаа үрчийлгэж,

–Намайг чинь Кежма орох замд биш, харин эсрэг тийшээ гол уруудаж явахад барьсан шүү дээ. Үгүй ээ, би Алфёров руу очихгүй, Канск руу л буцаагаад явуулчихна гэв.

–Канск орох зам байхгүй, их сайн бол нэг сарын дараа зам гарна. Кежмад бас шорон байхгүй, тэгэхлээр чамайг хаа хоргоож байх юм бэ? Өөрийнхөө талаар, бас Фридагийн талаар хөөцөлдөх гэж ирсэн гэдэг чиний мэдүүлгийг зөвшөөрсөн нь Алфёровт ашигтай байх юм. Тэр чинь онцгой явдал бүү болоосой гэж хүсэж байгаагаа надад өөрөө хэлсэн. Чамайг тэр доор барьсан явдал бол ямар ч падгүй. Рожковод завь байгаагүй, тийм учраас Код буюу Пашино хавиас завь хөлслөх санаатай байсан юм гэж хэлэхгүй юу.

–Алфёров миний оргосныг аль хэзээний зарлачихсан нь лавтай. Чамайг дуудахдаа хүрсэн юм чинь авах арга хэмжээгээ авчихаа л даа гэж Борис зөрөв.

–Тэглээ ч гэсэн энэ бол цорын ганц боломж хэмээн Саша өөрийнхөөрөө зүтгэж,

–Чи Братск орж чадахгүй, хамгийн түрүүн таарах тосгонд л чамайг бариад авна, тэгсэн цагт оргосон хэрэг гарцаагүй тулгана гэв.

–Тосгонуудаар би орохгүй.

–Тэгээд юугаа идэх юм бэ?

–Байвал чи надад жаахан идэх юм өг, гахайн өөх, хатаасан талх, ёотон энэ тэр...

–Мэдээж өгөлгүй яахав! Гэхдээ чи хичнээн юм авч явж чадах вэ, тэр чинь хэдий хэр хугацаанд хүрэлцэх вэ? Одоо өвөл юм чинь ой дотроос юм олж өл залгуулна гэж байхгүй. Чамд буу алга. Өлсөхийнхөө эрхэнд хамгийн түрүүнд тааралдсан тосгонд очоод л бууж өгнө дөө. Амь нас дүйсэн ажил гэдгийг чи ойлго. Алфёров дээр очих юм бол амь настайгаа үлдэнэ. Бас аргалаад гарчих боломж ч олдож мэднэ. Энэ чигээрээ цаашаа явах юм бол ой дотор амиа алдах юм уу, чамайг бариад авна. Тэгсэн цагт ямар ч горьдлого байхгүй болно.

Борис Сашагийн үгийг огт сонсохгүй байгаа мэт чимээгүй нүдээ анин хажуулах ажээ. Зүүрмэглэсэн байж ч магадгүй.

–Манайд хонох уу?

Соловейчик нүдээ нээлгүй толгой сэгсрэв.

–Хүний нүдэнд өртчихнө. Тэгвэл чи баларна.

–Миний тухайд санаа бүү зов.

Борис нүдээ нээж гэнэтхэн сэргэсэн янзаар,

–Хэрэв намайг энд байхыг харчихвал Алфёров энэ замаар мөшгинө. Уул нь би далаад километр явах хэрэгтэй, тэр хүрчихвэл надад туслах ёстой юм. Түүнээс гадна би чамд яаж гай тарьж байх вэ. Алфёров чамд урьдчилан анхааруулсан болохоор намайг оргодол гэж

мэдсэнгүй гэж чи хэлж чадахаасаа өнгөрсөн. Тэгэхлээр хоёулаа чи ч намайг хараагүй, би ч чамайг хараагүй! гэж тохирье. Нэг жилийн дараа ч бай, хоёр жилийн дараа ч бай, арван жилийн дараа ч бай, хэзээ ч юу ч болсон би ч чамайг хараагүй чи ч намайг хараагүй шүү гэв.

–За, яах л санж вэ, би бол ямар ч атугай чамайг алдаа хийж байна л гэж бодож байна. Чи хоёрхон цагийн дараа Кежмад байж байя гэвэл чадах л байна. Алфёров чамайг жаахан хоргоож зэмлэнэ, тэгээд л гүйцэх байсан болов уу гэж би бодож байна. Дахин хэлэхэд энэ бол цорын ганц боломж шүү гэж Саша өгүүлэв.

–Шийддэгээ шийдсэн хэмээн Соловейчик эрсхэн өгүүлээд,

–Чи надад өөх, хатаасан талх, ёотон олж өгч чадах уу? гэв.

–Өөх чадна, ёотон олохыг хичээе, талхаа бол хатаах хэрэгтэй, хэрвээ чи хүлээвэл болж л байна.

–Хүлээж чадахгүй нь. Хатаасан талхны оронд зүгээр талх аваад ир.

–Борис! Чи бодож үзээч, би чамаас гуйя. Чамайг яана гэж тооцоолж байгааг би ойлгохгүй байна. За яахав, чи Братск орж дөнгөх юм гэж саная... Тэр заяа нь бүтэхгүй, гэхдээ тэгж саная. Гэтэл дараа нь яах юм бэ?

–Тэндээс намайг хүмүүс Эрхүү рүү явуулж өгнө, тэгээд галт тэргэнд суугаад Москва руу яваад өгнө.

–Яах гэж?

–Үнэнийг хайх гэж.

Борис Сашад солиотой амьтан шиг санагдав. Ямар гээчийн үнэнийг хайх гэж байна вэ? Эсвэл юмаа нууж, дутуу хэлээд байгаа юм болов уу? Үнэнч нөхөд нь зам дагууд байгаа юм уу? Фридагийн найзууд байх нь уу? Далан километр явах хэрэгтэй гэж байгаа юм чинь Фролово, Савино, Усольцево гурвын аль нэгийг хүрнэ гэсэн үг. Гэтэл энэ гацаанууд цөмөөрөө арал дээр байдаг юм чинь Ангарыг яаж гатлах юм бол? Ангара одоохондоо хадаалаагүй ч гэсэн энд их түргэн урсгалтай болохоор мөд хөлдөхгүй. Тэглээ ч гэсэн ямар нэгэн тооцоо байж таарна. Энд, энэ цөллөгийн газар Сашагийн санаа аваагүй байгаа ямар нэгэн өөрийн гэх харилцаа холбоо, ямар нэгэн өөрийн гэх бололцоо байдаг бололтой. Тэр улсыг мань хүн бүхнийг чадагч, бүхнийг мэдэгч, бүхэнд шургалагч гэж дандаа боддог байжээ. Үнэн хэрэг дээрээ тийм биш, төр засгийг мэхэлж болох юм байна. Зида өөрт нь өөр арга зам санал болгож байсан. Соловейчикт бас Сашагийн мэдэхгүй өөрийн гэсэн арга зам байж мэдэх юм.

–Тосгон орчихоод ирэхэд чамд хэдий хэр хугацаа хэрэгтэй вэ?

Энэ бол шавдахыг хүссэн гуйлт. Саша бослоо.

–Гурван цаг орчмын дараа эргээд ирье.

–Би чамайг хүлээж байя.

Борис дахиад модоо налж нүдээ анив.

Баривчлага, шорон, цөллөг гээд үүний өмнө тохиолдсон бүх явдлыг одоо болж байгаа юмтай зүйрлэхийн арга алга. Тэгэхэд мань хүн ямар ч гэм буруугүй байсан, гэтэл одоо анх удаагаа хууль ёсыг зөрчиж байна. Анхааруулга авсан хэрнээ оргодолд тусалж байна. Борис мэдээжээр түүнийг илчлэхгүй, тэглээ ч гэсэн “хүн оргоход дөхөм үзүүлсэн” сэтгэлийн зовлонтой болох нь тэр. Борисын оргож байгаа нь ямар ч утга байхгүй, нэг бол замдаа баларна, нэг бол баригдчихна. Ийм болохоор дөхөм үзүүлсэн гэж ял хүлээх болбол давхар давхар харамсалтай болно.

Тэгсэн ч гэсэн мань хүн Борист туслах ёстой. Харин тосгонд нэг ч хүнд сэжиг авахуулахгүй байх л чухал. Суугаа айлаасаа өөх, талх гуйх уу? Хэнд өгөх гэж тэр билээ? Шууд өөрийгөө барьж өгөх баримт. Тусалж чадах цорын ганц хүн бол Зида. Өөрт нь байхгүй бол айлынхнаасаа авна. Зида хүнсний зүйл байнга худалдаж авдаг юм чинь ямар ч сэжиг төрөхгүй. Хэрчим өөх, талх юм уу гамбир, арав хорин чанасан өндөг хэрэгтэй, ёотон Зидад бий, өөрт нь бас Москвагаас ээжийнх нь явуулсан чихэр бий, давс...

Мань хүн Зидад “Ол! Надад хэрэг байна, яах гэж буйг бүү асуу, тэр тухай март” гээд л хэлчихнэ.

Зида үнэхээр юу ч асууж лавласангүй. Айлуудаар орж өөх, борцолсон мах, гамбир олж авчраад өндгөө чанаж, ёотон, чихэр энэ тэрийг нийлүүлэн сайхан боогоод нутгийн анчдын ойд үүрч явдаг зотон даавуу уутанд хийж өгөв. Ийм уутанд хийж өгч байгаагаас үзэхэд Зида гадарлаж байгаа нь тодорхой байв.

Саша гарахдаа эргэж хараад,

–Би чамаас юу ч аваагүй шүү гэж хэлэв.

Юу ч тохиолдсон, хэрэг байдал яаж ч эргэсэн Зидад огт холбогдолгүй байх ёстой. Зида толгой дохиж,

–Мэдлээ гэв.

Борис Сашагийн хөлийн чимээнээр нүдээ нээж өндийгөөд нойроо сэргээх мэт толгойгоо эргэлдүүлэн шилгээж, хүнсний зүйлийг өөрийнхөө үүргэвчинд шилжүүлж хийв. Гагцхүү давсыг авсангүй.

–Надад бий.

Тэгээд бослоо. Саша дэмнэж үүргэвчийг нь үүрүүлж өгөв.

–За найз минь, үүрд баяртай!

Үүргэвч нь садаа болоод Борис Сашаг дүй муутайхан тэврэв. Тэр хоёр бие биеэ үнсэв.

–Би маргааш өглөөгүүр ирээд энд байж байна. Чи хэрвээ болихоор шийдээд буцаад ирвэл хоёулаа энд уулзъя гэж Саша хэлэв.

–Болихгүй ээ гэж Борис өчөөд,

–Чи сэжиг ажиг авахуулаагүй биз? гэж асуув.

–Тэр тухай бүү санаа зов.

Оржоникизе Пятаковын комисст тохиолдсон явдлын тухайд сэтгэл дундуур хоцорчээ. Марк Александрович тэр комиссыг чухамдаа үйлдвэрээсээ хөөж зайлуулсан, бас Марк Александровичийн буруугаас болж Сталинаас хатуу зэм дуулсандаа сэтгэл дундуур байжээ. Тэгэхэд Сталин Марк Александровичийг дэмжсэн боловч түүний сэдсэн орон сууц, нийгэм ахуйн барилга байгууламжийг хууль ёсны болгосон ямар ч бичиг баримт байхгүй. Гагцхүү ам бий, гэтэл ам бол мартагдчихна. Албан ёсоор сайшаасан бичиг баримт байхгүй цагт Рязанов далайсан мэсний дор байгаатай адил байх юм.

Тийм учраас Марк Александрович үйлдвэрийнхээ ажил байдал, эх орны хар төмөрлөгийн аж үйлдвэрийн өмнө тулгарч байгаа асуудлуудын талаар өгүүлэл бичиж өгөөч гэсэн “Большевик” сэтгүүлийн газрын хүсэлтийг дуртай зөвшөөрчээ. “Большевик” сэтгүүл намын гол сэтгүүл учраас тэнд нийтэлсэн өгүүллийг нийлүүлэгч болон хоршдог үйлдвэрүүд удирдамж хэмээн хүлээн авч өөрийнх нь үйлдвэрийн ажилд тус болно. Түүнээс гадна тийм өгүүлэл өөрийнх нь сэдсэн барилга байгууламжийг нийтэд мэдэгдэж, тэгснээрээ түүнийг хууль ёсны болгох боломж олгоно.

Марк Александрович өгүүллийг хоёр оройн дотор бичив. Түүндээ дорх үндсэн санаануудыг тусгажээ.

Америкчууд тус үйлдвэрийн зураг төслийг яарч хийсэн учраас түүнийг залруулах шаардлагатай. Залруулбал зохих гол гол зүйлийг Марк Александрович дурджээ. Тэрээр үүний хамт америкчуудын шилдэг үлгэр загвартай манай төмөрлөгийн мэргэжилтэн нарыг өргөн дэлгэр танилцуулахыг уриалж, бид чухам юу юугаар тэднээс хоцорч байгааг нэгд нэгэнгүй заажээ.

Дорнод нутаг дахь хар төмөрлөгийн үйлдвэрийн гол зорилт бол нарийн мэргэжлийн тогтвортой ажилчид, инженер-техникийн ажилтан нарыг бататган суурьшуулах явдал мөн. Үүнээс үндэслэн орон сууц, нийгэм, соёл, ахуйн барилга байгууламжийг өргөжүүлэх шаардлага гарч байна. Марк Александрович нэгэнт гүйцэтгэсэн ажлаа (түүнээс болж комисс ирсэн) тоочиж, тэдгээрийг Намын Төв Хороо дэмжсэн (Сталины үгийг хэлж буй нь тэр ажээ) өөрсдийн ололт хэмээн тэмдэглээд үйлдвэр энэ ажлаа үргэлжлүүлнэ гэж бичжээ.

Марк Александрович төгсгөлд нь урагшгүй нийлүүлэгч нарыг ширүүхэн үгээр зад шүүмжилжээ. Уг өгүүлэл арван нэгдүгээр сарын дундуур сэтгүүлд гарч, Марк Александрович мөн сарын сүүлчээр Москвад Төв Хорооны Бүгд хуралд хүрэлцэн иржээ.

Бүгд хурал 1935 оны нэгдүгээр сарын нэгнээс эхэлж талх болон бусад хүнсний бүтээгдэхүүний тасалбарын системийг халах тухай ганц асуудал хэлэлцэв.

Уг хэлсэн хүмүүс 1928 оноос мөрдөж байгаа тасалбар хэдийгээр хүнсний зүйлээр бүрэн хангаагүй ч гэсэн хангамжийг нэгэн түвшинд хатуу барьж байгаа билээ. Одоо чөлөөт худалдаа тогтоохлоор зах зээл үүснэ, зах зээлийг яаж зохицуулахаа бид мартчихсан гэхчлэн санаа зовсон янзтай ярьцгаав.

Сталин үг хэлэхгүй, тэргүүлэгчдийн байранд чимээгүй сууна.

Бүгд хурлын сүүлчийн өдрийн завсарлагаанаар Марк Александровичийг танхимын үүдэнд байхад Оржоникизе, Киров хоёр түүн дээр ирэв. Оржоникизе инээмсэглэн,

–За, чамтай Сергей Миронович танилцъя гэж байна, чиний өгүүлэл аятайхан санагдсан гэнэ гэж хэлэв.

Киров Марк Александровичтай гар барилаа.

–Нээрэн ажил хэрэгч, сайн өгүүлэл байдаг шүү. Таны бичсэн зүйл шинэ районд төдийгүй хуучинд бас хамаарна. Боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах явдал одоо хаа сайгүй тэргүүн зэргийн асуудал болж байна. Америкчуудын сайн юмнаас суралцах хэрэгтэй гэж уриалсан чинь бас аятайхан санагдлаа. Суралцах тухайд бол хөрөнгөтнүүдээс ч суралцахаас ичихийн хэрэггүй. Ленинградын зарим үйлдвэрийг шүүмжилсэн тухайд гэвэл тэр байдлыг засна гэдгийг танд амлая.

–Баярлалаа. Тэр чинь л бидэнд хамгийн өндөр шагнал болно гэж Марк Александрович хариулав.

Оржоникизе,

–Манай энэ чинь бас мундаг дипломат. Өөрийнхөө хууль бусаар зарцуулж байгаа хөрөнгийг тэр өгүүллээрээ албан ёсоор хуульчилсан байгаа юм гэж сайн санааны үүднээс өгүүлэв.

–Хаанаас даа, Григорий Константинович минь, юу хийсэн, юу дэмжигдсэнийг л би зүгээр дурдсан юм... гэж Марк Александрович өчив.

Оржоникизе хариулж амжсангүй. Тэдний дэргэд Сталин хүрээд иржээ. Чухам аль талаас ирснийг ч тэд нар анзаарсангүй.

–Юун тухай маргацгааж байна?

–Нөхөр Рязановын өгүүллийн тухай ярьцгааж байна гэж Оржоникизе хариулав.

Сталин Кировыг алгасан Оржоникизе, Марк Александрович хоёр руу ёозгүй харж,

–Юун өгүүлэл вэ? гэж асуув.

–“Большевикийн” сүүлчийн дугаарт байсан гэж Киров хариулав.

–Уншаагүй юм байна гэж Сталин Киров руу бас харалгүй өгүүлэв.

Тэгээд цаашаа яваад өглөө.

Марк Александрович түүний араас нүд дагуулж, бараг хүрэн гэмээр бүдгэвтэр өнгийн цэрэг цамцтай яльгүй бөгтөр нарийхан нуруу руу нь харахдаа бахархах сэтгэл бялхаад ирлээ. Тун

сая ганцхан минутын өмнө мань хүн ТҮҮНИЙ дэргэд, Киров, Оржоникизе хоёрын дэргэд зогсоод тэд нар бүгд хурлынхны нүүрэн дээр юм ярьцгааж байлаа шүү дээ. Сталин “Большевикт” гарсан түүний өгүүллийг уншаагүй нь зүйн хэрэг, тэрээр бүгд хуралд бэлтгэж, тасалбарын системийг халах гэж бэлтгэж байсан юм чинь сэтгүүлийг унших нь битгий хэл гүйлгээд харчих ч цаг байгаагүй. Тэр өгүүллийг Киров уншчихсан, бас тэгээд магтаж байна, түүнээс илүү яах вэ дээ. Бас Оржоникизе нөхөрсөг харьцаж байгаа нь өөрт нь уурлахаа больсны шинж, өгүүлэл нь зохих үүрэг гүйцэтгэж Марк Александровичийн үйлдвэр дээрээ явуулсан үйл ажиллагаа ч хууль ёсны болчихлоо. Өөрөө дэмий санаа зовж байжээ. Бүх юм ёсоор боллоо. Аугаа их үйлсийн эрин үед аливаа ашигтай, аливаа жинхэнэ зүйл ТҮҮНИЙ мэргэн ухаан, ТҮҮНИЙ хүчирхэг гараар залагдаж байгаа учраас гарцаагүй ялан дийлнэ. За тэр, төлөөлөгч дүүрсэн үүдний танхимаар МАНЬ ХҮН алхалж явна, түүнд хэн ч зам тавьж өгөхгүй, алхам төдий ч хөдлөхгүй байгаа юм шиг хэрнээ зам чөлөөтэй байна. ТҮҮНИЙ өмнө зам чөлөөтэй, МАНЬ ХҮН зөөлхөн гутлаараа хөнгөхөн хөнгөхөн гишиглэн тайван зугуухан алхлахад хэн ч түүн рүү эргэж харахгүй байгаа юм шиг хэрнээ Сталин явж байна гэдгийг цөмөөрөө мэдэрч буй нь илт. Сталиныг тэргүүлэгчдийн байр луу очих хаалганы цаад руу ормогц Марк Александрович Оржоникизе хана налчихсан, чичирсэн гараараа боодолтой нитроглицеринээс нэг ширхгийг авч хэлэн дороо хийж байгааг сая анзаарав.

—Чи чинь яачихав? гэж Киров сандран асуулаа. Оржоникизе амьсгаа аваад,

—Зүгээр гэв.

Марк Александрович түүнийг сугадан авав. Оржоникизе гарыг нь аяархан хөндийрүүлэхэд,

—Григорий Константинович, энд эмчийн өрөө бий, тийшээ очъё...

—Юу ч хэрэггүй ээ, зүгээр болчихлоо.

—Үгүй, гэртээ харь. Явъя, би чамайг гаргаж өгье гэж Киров эрсхэн хэлэв.

Сталин царай өгөөгүй нь Кировын хувьд санаандгүй зүйл биш байв. Тэр хоёрын харилцаа бүр Сочид байхад нэгэнт муудаж, Сталин тэндээс түүнийг Казахстан руу чухамдаа хөөсөн юм. Киров есдүгээр сарын зургаанаас хорин еснийг дуустал Казахстанд байсан бөгөөд Ленинградод буцаж ирэхэд нь ДЯАКГ-ын дарга Медведь өөрийнх нь орлогч Иван Запорожец Медведьтэй өөртэй нь хүртэл ярьж тохиролгүй Москвагаас, төв аппаратаас өөрийнхөө хэдэн хүнийг авчирч улс төр нууцын хэлтсийн гол гол албан тушаалд дур мэдэн хуваарилчихаад байгаа тухай, ер нь Запорожец Москвагаар удирдуулдаг бие даасан хүн гэдгээ элдвээр харуулж байгаа тухай түүнд илтгэжээ. ДЯАКГ-т нэг нь мужийн намын хороонд, нөгөө нь Москвад захирагддаг хоёр дарга байж болохгүй, энэ бол тэсвэрлэшгүй явдал. Тийм учраас Запорожец болон орон нутгийн байгууллагатай тохиролцолгүй томилсон түүний хүмүүсийг нэн даруй шаардаж буцааж дуудуулахыг Медведь хүсэлт болгожээ.

Энэ бол ярвигтай асуудал. Тэр томилолтуудыг дээрээс зөвшөөрсөн нь лав. Аягүй бол Сталины шууд заалтаар ”сөрөг хүчний үлдэгдлийг үндсээр нь устгах” бас Кировыг чадах зорилгоор хийгдсэн байх. Тэднийг устгах ажлыг чи хийх дургүй байгаа бол чамгүйгээр хийчихнэ гэж байгаа үг, тэгээд л Запорожец биеэ даасан хүн гэдгээ элдвээр харуулж ядаж

байх нь. Запорожецийг буцааж авахыг шаардана гэдэг бол Сталинтай шууд харгалдана гэсэн үг. Зүгээр ч үгүй Сталин хэнийг ч хөндлөнгийн оролцуулдаггүй боловсон хүчний нарийн асуудлаар түүнтэй харгалдана гэсэн үг.

Хэдий тэгэвч Ленинградад мужийн намын хороонд захирагддаггүй бие даасан тийм байгууллага байхыг зөвшөөрнө гэдэг бол яваандаа аливаа эрх мэдлээ алдана гэсэн хэрэг.

Киров мужийн намын хорооны товчооны гишүүдийг, элдэв нарийн бичгийн дарга, техникийн туслах ажилтан байхгүйгээр, протокол хөтлөхгүйгээр зөвхөн товчооны гишүүдийг өрөөндөө цуглуулаад Медведийг нөгөө мэдээллээ дахин ярь хэмээж товчооны гишүүдийг тэр тухай санал бодлоо хэлэхийг хүсэв. Запорожец болон түүний талын хүмүүсийг буцааж авахыг шаардъя гэсэн нэгдмэл нэг санал гарлаа.

Киров харилцуураа авч Москватай холбуулав.

—Одоо илтгэе гэж Поскрёбышев хариулав. Нэлээд удаан хүлээв. Кировын өрөөнд нам гүм, тэнд байгаа хүмүүс Сталин утсаа авахгүй байгаа нь санаандгүй хэрэг биш гэдгийг ойлгон цөм чимээгүй байцгаав. Сталин тэгж тэгж утсаа авав.

—За, юу гэв.

—Нөхөр Сталин, Запорожец ДЯАКГ-ын дарга Медведид захирагдахгүй дураараа дургиж байна. Мужийн намын хорооны товчоо Запорожецийг Ленинградаас татаж авахыг шаардаж байна гэж Киров хэлэв.

Сталин чимээгүй байзнаснаа,

—Чухам яаж дураараа дургиж байгаа юм бэ? гэв.

—Сүүлчийн удаа гэхэд л Москвагаас, Ягодаас таван хүн авчраад Медведид мэдэгдэхгүйгээр тэдний улс төр, нууцын хэлтэст хариуцлагатай албан тушаалд хуваарилан тавьсан байна... гэж Киров хэлэв.

—Энэ чинь ДЯАКГ-ын аппаратын доторх дотоод шилжүүлэг байна шүү дээ гэж Сталин хэлэв.

Киров уурлан алганыхаа ирмэгээр ширээгээ цохиж,

—Тэгвэл би чинь мужийн намын хорооны нарийн бичгийн дарга мөн юм уу, биш юм уу? гэж ширүүлэв.

—Нялх хүүхдийнх шиг иймэрхүү асуулт ямар хэрэг байна? хэмээн Сталин зөрж,

—ДЯАКГ бол шинэ газар, тийм учраас аливаа шинэ газрын нэгэн адил тэнд чинь боловсон хүчнээ нааш нь цааш нь шилжүүлэх явдал зайлшгүй гарна. Тэр болгоныг орон нутгийн бүх байгууллагатай зохицуулж байх арга чухамдаа байхгүй гэв.

—Мужийн намын хорооны товчоо ч гэсэн, би өөрөө ч гэсэн Запорожецийг татаж авахыг хатуу

шаардаж байна гэж Киров өчив.

–Би чадах чинээгээрээ тайлбарлалаа, үүнээс илүү чадахгүй гэж Сталин зэвүүн хэлэв.

Тэгээд харилцуураа тавьчихлаа. Нэг хэсэгтээ цөм чимээгүй сууцгаав. Тэгтэл Киров Медведь рүү эргээд,

–За тэгвэл Филипп, танай байгууллагын эзэн ганц чи шүү, мужийн намын хорооны товчоо чамаас өөр хэнийг ч мэдэхгүй гэж мэд. Запорожецийг дураараа загнавал тухай бүр цаагуур нь тас цохиж бай, бид чамайг дэмжинэ гэж хэлэв.

Киров Сергог гэр лүү нь хүргэж өгөөд бүгд хурал дээр буцаж ирэв. Завсарлага дуусаж хонх дуугаран бүгд хурлынхан танхимд орцгоож байв. Харин Марк Александрович Кировыг хүлээзнэж байжээ.

–Сергей Миронович, уучлаарай, Григорий Константинович яаж байна?

–Одоохондоо гайгүй л юм шиг байна, орондоо хэвтээд өгсөн, Зинаида Гавриловна эмч дуудаж байгаа.

Гэтэл Оржоникизе эмч дуудахыг хоригложээ. Тэрээр бие нь гайгүй болж хэвтрээс боссон боловч бүгд хурлын шийдвэрийн төслийг мэдэх учир өөрийг нь байсан байгаагүй санал хураачихна гэж бодоод тийшээ буцаж очихгүй гэж шийдэв. Олбогт сандалд суугаад бодлогошров...

Тэрээр өнөөдөр хурлын байрны үүдний танхимд Сталинтай хоёрхон минут ярилцах хооронд түүний Кировт яаж ханддаг үнэн нүүр царайг тодоос тод ойлгожээ. Оржоникизе Сталиныг сайн мэддэг учир Сталин хүнтэй ярьж байхдаа түүн рүү харахгүй байна гэдэг юу гэсэн үг болохыг бас мэднэ...

Харуй бүрий бууж байрны гэрэл асаах үед Зинаида Гавриловна түүн рүү шагайв.

–Чи яаж байна?

–Зүв зүгээр, гэхдээ миний гэрлийг битгий асаагаарай, би ганцаараа суузномаар байна гэж Оржоникизе гуйв.

Тэрээр бодол болон сууна. Ленинградын ДЯАКГ-т хачин томилолт, шилжүүлэг болж байгаа тухай Будягины мэдээлсний дараа мань хүн Сталинтай Кировын тухай ярилцаж байдлыг тандах гэж хэд хэдэн удаа яриа өдсөн боловч Сталин зайлсхийгээд болохгүй байсан хэрнээ хожим өөрөө гэнэтхэн тэр тухай яриа сэдсэн билээ.

Казахстаны тариа хураалтын явцын тухай Кировын ирүүлсэн мэдээллийг Улс төрийн Товчоон дээр сонсож байхад Сталин хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүйгээр юмны завсраар санаандгүй мэт,

–Би нөхөр Кировыг Төв Хорооны нарийн бичгийн даргынх нь хувьд Москвад шилжиж ирэх

санал хэлсэн боловч тэр татгалзсан. Нэг хотод хичнээн жил суудаг юм бэ? Найман жил! Боллоо биш үү! Кировыг Ленинградад байлгаж, тэгтлээ баярхахдаа бид хүрээгүй. Киров бол бүх улс орны зиндааны хүн, бүх намд маань хэрэгтэй гэж хэлсэн юм.

Тэгээд өөр юу ч хэлэлгүй дараачийн асуудалд шилжжээ.

Харин хурлын дараа бүх хүн тарж өрөөнд Сталин, Каганович, Молотов нар үлдсэн, бас Куйбышев үлдсэн байл уу даа, тэгэхэд Сталин Оржоникизед,

–Та хоёр найз юм чинь чи Кировтой ярилц, цаадах чинь Москвад шилжиж ирэг л дээ. Төвийн удирдлагад орос хүн хэрэгтэй байна. Чи бид хоёр гүрж, Каганович еврей, Рузутак латви, Микоян армян. Орос хүн хэн байна вэ? Молотов, Куйбышев, Ворошилов, Калинин дөрөв. Цөөдөж байна гэсэн билээ.

Кировыг Казахстанас буцаж ирсний дараа Оржоникизе Ленинград орж Сталины саналыг Кировг дамжуулсан. Киров бас л татгалзсан. Тэрээр Сталинтай Сочид шөргөөлцсөн тухайгаа болон Запорожецээс болж дахин сөргөлдсөн тухайгаа ярих зуур,

–Запорожецийг Ленинградад дураар нь хэрхэвч дургиулахгүй гэж итгэлтэй тайван хэлсэн.

Тэд нар цөмөөрөө яасан гэнэн байж вэ. Өөрөө ч гэсэн, Будягин ч гэсэн, Киров ч гэсэн мөн гэнэн байж шүү. Киров Запорожецийн өмнө бууж өгөхгүй гэдгийг Сталин ойлгохгүй байхдаа яах вэ дээ? “Үндсээр нь уудалж устгана” гэдэг бол зөвхөн халхавч, Запорожец тэнд юу ч илрүүлж устгаж чадахгүй, тэгүүлэх ч үгүй.

Одоо яах вэ?.. Цаг хожихоос өөр ямар ч арга алга. Кировыг Москвад үгүй ядахдаа хэдэн өдөр юм уу ганц долоо хоног саатуулах хэрэгтэй. Бүхнийг эргэцүүлэн бодож нөхөдтэйгөө зөвлөлдөх хэрэгтэй, магадгүй Кировыг Москвад шилжиж ирүүлэхээр ятгаж дөнгөх ч юм билүү. Түүнээс гадна гол нь Киров Москвад гэнэтхэн саатчихвал Сталин хар аван болгоомжилж, тэгээд өөрөө ухралтад орж болзошгүй, бас Запорожецийг татаж авч болзошгүй.

Киров бүгд хурлаас бараг арван нэгэн цагийн үед ирэв.

Оржоникизе өөрөө хаалга онгойлгож өглөө.

–Эдгэчихээ юу? хэмээн Киров орох зуур хөгжилтэй асуугаад,

–Бие яаж байна? гэв.

Оржоникизе олбогт сандалд сууж амьсгаагаа дарлаа.

–Муу байна, Серёжа минь, барагтайхан байна, чи цөөхөн хоног надтай хамт байгаач.

Юмаа цүнхэндээ хийж байсан Киров эргэн харж,

–Чи юу ярьж байна вэ? Нөгөөдөр, арван хоёрдугаар сарын нэгэнд би намын идэвхтэний хурал

дээр илтгэл тавина... Бүгд хурлын тухай... гэв.

–Илтгэл ер яах вэ дээ... хэмээн Оржоникизе шүүрс алдан,

–Чудов, Кодацкий энэ тэр илтгэл тавьж чадахгүй юм уу? Чи надтай байзна л даа, Серёжа, ахиад уулзахгүй ч болчих юм билүү... гэв.

Киров түүн рүү очиж гарыг нь бариад нүд рүү нь эгцлэн харж,

–Энэ бодлоо хол хая. Ер нь орондоо ороод эмч дууд. Зүрхний бахны хууч хөдлөхлөөр дандаа ингэж айдас хүрдэг юм. Биеэ барь. Унаа яаж дуудах вэ? гэв.

–Би өөрөө утасдъя.

Оржоникизе сандлаасаа босож зэргэлдээх өрөө рүү ороод дотуур утсаараа гарааш руу залгаж өөрийнхөө жолооч Барабашкинтай ярья гэв.

–Василий Дмитриевич, машинтайгаа хүрээд ир, Кировыг галт тэрэгний буудал дээр хүргэж өгнө шүү гэчихээд харилцуураа гараараа таглан байж,

–Гэхдээ түүнийг галт тэрэгнээс нь хожимдуулчихаарай. Ойлгов уу? гэж маш аяархан хэлэв. Оржоникизе зоогийн өрөөнд эргэж ирэхэд Киров юмаа хэдийн цүнхэндээ хийж пальтогоо өмсчихөөд Зинаида Гавриловнатай яриад зогсож байв.

–Чи надтай гурав өнжчихсөн чинь дээр, Серёжа, тэг л дээ! гэж Оржоникизе гунигтай өгүүлэв.

–Даанч чадашгүй нь, би чамд учрыг нь хэлсэн шүү дээ, арван хоёрдугаар сарын нэгэнд идэвхтэний хуралтай.

Доор байрны үүдэнд машины дохио огцомхон дуугарав.

Киров Оржоникизег тэвэрч үнсэв. Зинаида Гавриловнаг бас тэвэрч үнсээд түүнд,

–Энүүнд дөрлүүлээд байхын хэрэггүй, албадаж эмчлүүлж бай хэмээн нөхөрсгөөр даалгав.

Цүнхээ аваад яаран гарав. Цаг арван нэг хагас болж байв.

Барабашкин төв шуудан арай хүрэлгүй машинаа зогсоогоод ухасхийн гарч хамрынх нь дээврийг сөхөв.

–Яачихсан бэ?

–Бензин тасалдаад байна, одоохон янзалчихъя, Сергей Миронович.

–Үгүй ээ, би хүлээхгүй.

Трамвайны буудлын ойролцоо зогссон нь Барабашкины алдаа болжээ. Галт тэрэгний гурван буудал руу явдаг дөрвөн ноймерын трамвай тэр зогсоол руу яг ирж таарсан тул Киров тэр лүү амжаад орчихлоо. “Стрела” галт тэрэг хөдлөхөөс ганцхан минутын өмнө вагоны үйлчлэгч түүнийг амжиж оруулжээ.

Саша үүр хаяараагүй байхад гэрээсээ гарч, өчигдөр Борисоос салсан газар дээрээ өглөө эртлэн ирлээ. Ёроолд нь хажуулж байсан нөгөө мод энэ байна. Саша ирчихээд байгаагаа Соловейчикт мэдэгдэх гэж нэгэнтээ шүгэлдсэнээ Жучокийг хоёр удаа турхирч хашгирсан боловч ямар ч хариу гарсангүй. Саша ой дундуур бүрий болтол бэдэрсэн авч Борисын бараа сураг байдаггүй, тэгэхлээр буцахгүй гэж шийдсэн байх нь. Тэрээр дараа дараачийн өдөр нь явсан замаа өөрчлөн тойрох хүрээгээ тэлсээр байв. Гачуурын мөчир дээр цас хэдийн памбайн хөвсийж унуул мод, мөстөн хадаалсан намаг, ойн чөлөөний газар энэ тэр сэвсгэр цасанд дарагджээ. Саша явдалдаа түүртэн байн байн амсхийж чих тавин чагнавч ой анир чимээгүй хэвээр. Гагцхүү хөлдүү мод хаа нэгтээ чийхарч, загалмай бялзуухай мөчирт тогтсон хярууг бутаргаж, цөмсөн шогшгой, баравгай энэ тэрийг цас руу унаган гачуураас гачуурт нисэхдээ чад чад тагнайдахаас өөр дуу авиа үгүй.

Саша нэг удаа хэвтгэртээ байсан чандагыг санаандгүй үргээчихсэнд цаадах нь хоёр чихээ хулмайлан моддын хоорондуур харайлгажээ. Бас хэрэм тааралдана. Сагсгар сүүлээ агсчихаад мөчир дээр нь ил суучихсан, урд хоёр хөлөөрөө шогшгой түргэн түргэн эргүүлэн самар цөмж, Сашагийн дээрээс эгцлэн харж байхыг үзвэл энэ жилийн хашир суугаагүй зулзага бололтой. Нэг удаа оготнотчилж яваа үнэг харсан, тэр үнэг цасан дээгүүр яаралгүй шогшиж, цасан дор энд тэнд оготно, хулгана часхийх вий хэмээн байн байн чимээ чагнан зогтусаж, тэгээд часхийх чимээ сонсвол тэр даруй тийшээ харайлган очиж цас ухаж байжээ. Саша сойр яаж хоолоо олж идэж байгааг бас нэгэнтээ харжээ. Шинэхэн цасан дээгүүр болгоомжтой соёгонож байгаад арцны сахал, хунгарт хараахан дарагдаагүй хар нэрсний найлзуур, заримдаа нялх нарсны оройноос шилмүүс тасдаж идэх аж.

Саша долоо хоног ойгоор хэсүүчилсэн боловч Соловейчик үзэгдэж харагдсангүй. Тэгэхлээр холдоод явчихсан хэрэг, эсвэл ой дотор хөлдөх, өвчин тусах, мөс рүү цөмөрч ойчихын нэг болсон юм уу төөрөөд өлсөж үхсэн байх.

Лав л баригдаагүй. Хэрвээ баригдсан бол хэн хүнгүй мэдэх байсан. Оргоно гэдэг бол үйл явдал, оргодлыг барина гэдэг бол түүнээс ч мундаг үйл явдал. Хэн тусалсан, хэн нуусан, хэн хоол унд өгсөн? гэхчлэнгийн асуулт байцаалт эхэлдэг учраас тийм сонин мэдээ Ангараар нэг тархана.

Мозговын цөллөгийнхөн ч гэсэн Соловейчикийн оргосон тухай бас шуугицгаав. Гэхдээ түүнийг Сашагаас өөр таних хүн байхгүй, Саша тэр танилынхаа тухай элдвийг ярьдаггүй байсан учир тэд нар оргоод ямар ч үр дүнд хүрэхгүй, гагцхүү балрах замдаа орно гэхчлэн ерөнхий юм ярьцгаажээ. Сибирээс дөнгөөд гарлаа ч гэсэн манай нөхцөлд нууцаар байх боломжгүй учраас мөн адилхан баларна. Энэ тухайд цөм санал нэг байжээ.

Үүний хамтад Соловейчикийн оргосон явдал ул мөргүй өнгөрөхгүй гэдгийг бас бүгдээрээ ойлгож байв. Үүнийг зүгээр өнгөрүүлнэ гэдэг бол цаашдаа оргохыг өөгшүүлсэн хэрэг болно. Оргодлыг шийтгэх аргагүй бол үлдсэнийг нь суурьшсан газраас нь зайлуулах, хэд гурван мөнгө олох ажилгүй болгох зэргээр шийтгэх хэрэгтэй. Оргосон хүн болгоны төлөө бусад нь хариуцлага хүлээнэ, тийм учраас хүн оргохоос өөрснөө урьдчилан сэргийлж байх ёстой

гэдгийг цөллөгийнхөн мэдэж байвал зохино. Тэгтэл үнэхээр удалгүй Рожковский цөллөгийнхнийг өөр тосгонуудаар тараан суурьшуулжээ.

Тэндээ Мозговад Каноров гэгч нэг эр, бас хүмүүсийн ярилцахыг сонсвол бараг л мянга есөн зуун таван оноос намын гишүүн яваа Звягуро гэдэг хачин овогтой нэг авгай хоёрыг ирүүлжээ. Тэр авгайн нэр Лидия Григорьевна. Шүд буйл нь түрсэн царай дортой, хуучны дүр төрхтэй тэр авгай Тарасик гэдэг зургаан настай хөвгүүнтэй цуг иржээ. Түүнийг чаргаар авчирч таарчээ. Тэрээр улаачийг Сашагийн суудаг айлын дэргэд зогсоож өөрөө гэрт орж ирээд,

–Соловейчик надад таны тухай ярьж байсан юм. Байр хөлслөхөөр ямар айл байж болохыг та хэлж өгөхгүйсэн болов уу? гэжээ.

–Бодох хэрэгтэй юм, та наашаа ор, суу гэж Саша хариулав.

–Би улаачийг буцаах ёстой юм.

Тэр хоёр гадагшаа гарлаа. Алчуураар ороосон Тарасик чарган дээр сууж байв. Лидия Григорьевна түүнийг чарганаас чангаан буулгаж, Саша тэдний ачаа бараа гэх дээсээр боосон хоёр халцгай чемоданыг аваад гурвуулаа байшинд буцаж оров. Гадаа чарганы мөр хяхраад улаач яваад өглөө.

Лидия Григорьевна Тарасикийн алчуурыг задалж, хүүгийн өмссөн малгай, үстэй дээлэрхүү юм хоёрыг тайлаад вандан дээр суу гэж хэлэв. Тарасик Сашаг харан харан байж вандан руу суулаа.

Саша гал тогооны өрөөний хаалгыг нээж гэрийн эзэгтэйг дуудав. Зочдын өрөөнд эзэн, эзэгтэй хоёр цугтаа орж ирлээ.

Саша Лидия Григорьевнаг зааж,

–Энэ хүн миний танил байгаа юм, хэнийд суулгах вэ? гэж асуув.

Эмгэн хөвгүүнийг хараад,

–Ач хүү юм уу? гэв.

–Ач хэмээн Лидия Григорьевна хөмсөг зангидав.

–Хүүхэдтэй хүнд ч байр олоход хэцүү дээ. Энэ хүүхдүүд чинь дүрсгүйтээд болдоггүй юм...

–Энэ дүрсгүйтдэггүй хүүхэд гэж Лидия Григорьевна өгүүлэв.

–Хэн мэдэх вэ дээ гэж эмгэн амандаа бувтнав.

–Танай энд хүүхэдтэй цөллөгийн хүн ирж байгаагүй гэж үү? хэмээн Саша асуув.

Эзэгтэй хариу дуугаралгүй нөгөө хүүг харсаар байв.

–Нэр чинь хэн билээ?

–Тарас гэдэг.

–Брюхановынх байр өгч таарна гэж өвгөн хэлэв.

–Брюхановын охин жаахан мэдрэл муутай.

–Томоотой, охинд гар хүрэхгүй л дээ. Лидия Григорьевна дахиад хөмсөг зангидав.

–Брюхановынхоос өөр оруулчих айл байна уу? Эмгэн бодол болсноо,

–Сизых яах бол? гэж өвгөнөөсөө асуув.

–Балгадаг эр дээ гэж өвгөн дэмжингүй өгүүлэв.

–Үгүй, үгүй, тэгвэл хэрэггүй, Тарасик согтуу хүнээс айдаг юм.

–Чи шилэмхий хүн юм аа гэж эмгэн дурамжхан өгүүлээд Саша руу хандаж,

–Чи Верхотуровынд очоод ир, багш хүүхнийхээс холгүй байдаг айл гэв.

Верхотуровынд очих замд Лидия Григорьевна,

–Хүүхэд хэнд ч саад болохгүй атал хүүхэдтэй хүнд байр олоход хэцүү юм. Хүүхдээс биш өөр юмнаас айцгааж байгаа хэрэг. Хэрвээ намайг бариад явчих юм бол хүүхэд тэр айлд хоцорно гэсэн үг. Тэгээд дарга нар түүнийг өнчин хүүхдийн газар явуултал нэг хоёр жилийн хугацаа өнгөрч мэднэ. Өргөдөл чирэгдэл болж хөөцөлдөх хэрэгтэй болно, гэтэл эд нар чинь бичиж чадахгүй улс гэхчлэн ярьж явав.

Верхотуровынх сард гучин рубль төлөхийг шаардав. Лидия Григорьевна шууд татгалзах гэж байгааг Саша царайгаар нь мэдээд тохойноос түшин,

–За яахав, эд нар юмаа аваад өнөөдөр танайд ирнэ гэж хэлэв.

Лидия Григорьевна дурамжхан байв.

–Та миний төлөөнөөс дэмий зөвшөөрчихлөө, би төчнөөн мөнгө өгч чадах ч үгүй, өгөх бодол ч алга.

–Намайг зөвшөөрлөө гээд та заавал түүнийг дагаж байх албагүй, больё гэвэл та бидний дурны хэрэг. Манайд ганц хоёр цаг байж биеэ амрааж, юмхан идэж уу, би тэр хооронд дахиад жаахан хайя. Хэрэв хямд төсөр юм олбол та өөрөө үзээд шийднэ биз. Одоо өөр юм олохгүй бол Верхотуровынд нэг хэсэгтээ орзнож бай, тэгээд өөр байр хайцгаая.

–Верхотуровынд суух тухай ярихын ч хэрэг алга, би дөнгөж хорин тавхан рубльтэй. Ер нь ямар жигтэйхэн үнэтэй юм бэ? Рожковод байхдаа би арван таван рубль л төлж байсан гэж

Лидия Григорьевна хэлэв.

–Энд илүү үнэтэй гэж Саша толгой дохиод,

–Рожково бол бөглүү газар. Мозгова чинь Кежмагийн хажууханд байгаа юм, Кежма районы төв болохоор байрны үнэ өндөр. Би хорин рубль төлдөг юм, таныг хүүхэдтэй гээд арваар ахиулчихаж байна. Мөнгөний тухайд гэвэл би танд цөөхөн хэдийг зээлүүлэе, дараа өгнө биз гэв.

–Би танаас мөнгө авахгүй хэмээн Лидия Григорьевна зөрж,

–Ярославльд байдаг ач дүү маань надад мөнгө явуулдаг юм, гэтэл одоо шуудан дээр бөөн холион бантан үүснэ, хаяг солино гэж юу байдгийг би эрхбиш мэднэ, хагас жилийн дараа юм авбал их юм болох байх. Рожковод байхдаа би юм оёж хэдэн мөнгө олдог байсан юм. Гэрийн эзэгтэй оёдлын машинтай байсан, одоо эндээс машин олоо ч уу, үгүй ч үү? гэв.

–Манай энд гоёхын хүслэнд автсан бүсгүйчүүл элбэг, районы сэхээтнүүдтэй л эн дүйх гээд байх нь тэр. Юм оёулах хүн зөндөө гэж мэд. Машин хоёулаа олно оо.

–Тэглээ ч гэсэн бас л Рожковынхон шиг хөлсийг нь өндөг, цөцгий, загас энэ тэрээр төлнө биз. Дүү маань надад сард хорин рубль явуулдаг юм, би тэр анзаанд л төлж чадна.

Саша Лидия Григорьевнаг гэртээ авчирч, Тарасик тэр хоёрыг цайгаар дайлахыг эзэгтэйд захиад өөрөө Зида руу явав. Зида энэ тосгонд танихгүй хүн байхгүй учраас боломжийн зөвлөлгөө өгч магад.

Хаалга нь онгорхой хэрнээ Зида эзгүй байв. Зууханд гал цоргошиж ширээн дээр ном, дэвтэр дэлгээтэй байхыг үзвэл сургуулиасаа ирчихсэн нь илт. Зида “Хүүхдүүд гэртээ хичээлээ давтана гэж байхгүй, номоороо гүцтэй сүү таглачихна, дэвтрийнхээ цааснаас ураад тамхи ороочихно..” гээд ном дэвтрээ авч харихыг хориглон хичээлийн дараа хүүхдүүдээ үлдээж байгаад даалгаврыг нь шахаж хийлгэнэ.

Саша хүүхдүүдийн турьхан бичигтэй дэвтрийг өөрийн эрхгүй харж байтал хулдаасан хавгастай нэг зузаан дэвтэр дээр хараа нь тусав. Түүний Москвад дээд сургуульд байхдаа хэрэглэдэг байсны ижил жинхэнэ зузаан дэвтэр. Саша түүнийг өөрийн эрхгүй нээв.

Бичээстэй зүйлийг уншаагүй боловч дотор нь байгаа наймдугаар сар, есдүгээр сар, аравдугаар сар, арван нэгдүгээр сар гэсэн үгнүүд дор “С” - энэ бол мань Саша, “В, С.” - Всеволод Сергеевич - мэтийн товчилсон үсэг, нүдэнд торсон “Тэрээр өчигдөр хэлэхдээ”, “Тэр бол маш зоригтой, ариун сэтгэлтэй хүн” гэхчлэнгийн зүйлийг үзмэгц энэ дэвтэр Зидагийн өдрийн тэмдэглэл гэдгийг Саша ойлгов. Тэр даруй дэвтрийг бушуухан хаах бодол төрөв. Бусдын өдрийн тэмдэглэлийг нууцаар уншихдаа хүрч хэнээ алдаж яахин болох вэ! Тэглээ ч гэсэн... Хэрвээ Москвад хуучин янзаараа аж төрж байсан бол мань хүн бусдын өдрийн тэмдэглэлийг зүрхэлж уншихгүй. Харин энд, ийм байдалтай байхад... Ядахдаа Зида өөрийнх нь тухай юм бичсэнийг ч хэлэх үү! Юу бичээ бол? Цаасанд итгэхийн хэрэг юу билээ? Энд юу бичээтэй байгааг өөрөө заавал мэдэх ёстой, түүний аль ч алхам, аль ч үгийг

юу гэж ч гуйвуулж мэднэ. Гай хаанаас гараад ирэхийг байг гэхийн газар байхгүй, тэр ч байтугай өөрт нь хайртай хүүхний зүгээс ч гай гарч болно. Ер нь ч мань хүн энэ хүүхний тухай чухамдаа юу мэдэхсэн билээ? Яагаад энд байна вэ?

Энэ бөглүү нутагт? Тэрээр өрөөн дотуур хэд алхав.

Бас “тэр бол зоригтой, ариун сэтгэлтэй хүн” гэсэн чинь юу гэсэн үг вэ? Соловейчикт хүнс залгуулж, оргодлыг барьж өгөөгүй гэдгийг битүүдээ хэлж байх нь уу! Мозгонад байгааг цөллөгийнхнийг түйвээн бусниулахад энэ хоёр үг л хүрэлцээтэй. Мань хүн энэ хүүхэнд итгэснээс болоод хөндлөнгийн хүмүүс зовлонд нэрвэгдэж мэдэх нь. Зида хэнд ч хар буруу санаагүй нь мэдээж, гэхдээ бичихийн хэрэг юу байна? Гуч шахаж байгаа хүүхэн чинь нялх охин биш шүү дээ! Өөрийнх нь байдлыг үнэнхээсээ ойлгохгүй байна гэж үү! Өдрийнхөө тэмдэглэлийг яагаад ширээн дээрээ орхичихов? Санаандгүй тэгээ юу? Далд хийхээ мартчихаа юу? Хөнгөмсөгдөх нь тэр үү?

Саша өрөөн дундуур дахин хэд алхсанаа хусны хагадаснаас дурсыг нь хуулж аваад зуух руу хаяхад галд төөнүүлсэн үйс хоромхон зуур атиран хуйларснаа дараачийн хоромд дүрсхийн аслаа.

Тэмдэглэлийг үзэх үү? Өөрийнх нь тухай юу бичсэнийг уншчихаад, Зида гэж хэрэг дээрээ чухам хэн болохыг нэгмөсөн сайтар мэдээд авах уу? Гэхдээ ингэсэн байх юм бол мань хүн шударга хүн, үл бүтэх этгээд хоёрыг заагладаг заагийг давсан хэрэг болно. Гэвч нэгэнт оройтжээ, мань хүн дэндүү удаан тээнэгэлзсэн байна... Гадаа хашаан дотор Зидагийн хөлийн чимээ гарснаа үүдний пинд орж ирж хөлөө арчих нь сонсогдов. Тэгээд өөр лүү нь инээмсэглэсээр орж ирлээ.

–Удаан хүлээв үү?

Саша хариуны оронд тэмдэглэл рүү дохиж,

–Энэ юу юм бэ? гэв.

Түүний дуунд уурласан янз байхыг мэдээд тэмдэглэлийн дэвтрийг нь нээж үзсэнийг ойлгонгуут Зида нэгэнтээ самгардсанаа Саша руу хиргүй тунгалаг харцаар шулуухан харж,

–Миний өдрийн тэмдэглэл гэж хэлэв.

–Яах гэж үүнийг хөтөлдөг юм бэ? Зида хэсэг зуур түгдрэв.

–Чамайг гомдоочихмоор юм энд байна уу?

–Би бусдын тэмдэглэл уншдаггүй. Гэхдээ... Чи бодвол миний тухай ч гэсэн ямар нэг юм бичдэг байлгүй?

–Тийм, бичдэг. Саша түүн рүү харснаа,

–Зида, чи яагаад энд байгаа юм бэ? гэж асуув.

Цаадах нь хариу хэлэхгүй доошоо тонгойгоод чимээгүй болчихов.

–Ямар салхиар энд хүрээд ирсэн хүн бэ? гэж би чамаас асууж байна.

–Би тэр тухай чамд хэзээ ч хэлэхгүй гэж Зида шивнэв.

–Тэр бол чиний дурын хэрэг, гэхдээ миний тухай юу бичиж байдгийг чинь би мэдэж авах ёстой.

Хүүхэн түүн рүү дэвтрээ сарвайж,

–Унш гэв.

–Би чиний тэмдэглэлийг уншихгүй. Харин чи миний тухай бичсэн бүх хуудсаа урж аваад энэ зуух руу хийчих. Тэгээд хойшид миний тухай битгий юм бичээрэй. Би үүнийг л чамаас гуйя. Өөрийнхөө байдлын тухай би чамд нэгэнт тайлбарласан, харин чи юу ч ойлгоогүй нь тоогүй байна.

Зида бодлогошрон дэвтрээ эргүүлж, хэдэн хуудас нугалаад Саша руу сарвайж,

–Чиний тухай бичсэн юм энэ байна, унш гэв.

–Уншихгүй гэдгээ би чамд тов тодорхой хэлсэн. Урж аваад шатаа.

Тэрээр ямар хэрцгий шаардлага тавьж байгаагаа ойлгож байв. Гэвч өөр арга байсангүй! Соловейчик оргож байж, тэртэй тэргүй зовж байгаа хүмүүст хичнээн лай нэмж тарьсан билээ дээ. Энэ хүүхний хөнгөмсөг зангаас болж өөр ямар нэгэн хүнийг зовлонд нэрвэхийг тэрээр эс хүснэ.

Зида зуух руу очиж явган суугаад ширмэн таглааг нь онгойлгосноо тэмдэглэлийнхээ дэвтрээс нэг хуудас тасдан авч гүйлгэж хараад хумхи базаад гал руу шидчихэв. Дараа нь хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх... хуудсыг мөн уншиж үзээд базаж гал руу хийв. Тэрээр Сашагаас буруу харан зуухны өмнө сөхрөн суугаад дэвтрийн хуудаснуудыг тасдан авч уншиж үзэлгүй гал руу хумхин шийднэ. Тэмдэглэлийн сүүлчийн хуудаснууд Сашагийн тухай байсан бололтой, эсвэл юу ч байсан хамаагүй болчихсон юм уу, Зида хуудас алгасалгүй урлаа. Тэгснээ гэнэтхэн,

–Яасан халуун юм бэ! гэж өгүүлэв.

Саша түүнд хувцсаа тайлах ч зав өгөөгүй, цаадах нь гаднаас орж ирсэн чигээрээ үстэй дээлтэй, эсгий гуталтай, алчууртайгаа байж байгааг мань хүн сая л анзаарав.

Тэрээр одоо бүсгүйг өрөвдөн өөрийгөө зүхэж эхлэв.

Яасан муухай, яасан шившигтэй билээ! Өөрийнх нь бодож олсон энэ тарчилгаа хэзээ дуусахаа үзэхийг хүлээж ядав. Зида босож дэвтрийнхээ үлдэгдлийг ширээн дээр тавиад,

–За ингээд гүйцлээ! гэж доголлон нулимстай өгүүлэв.

Саша тэднийхээс гарлаа. Муухай, ээ бас муухай юм боллоо! Ой гутам! Гэвч мань хүн ингэхгүй байж яаж чадахсан билээ! Одоо бол шинэ хуулиар амьдарч байгаа хүн юм чинь. Зида энэ байдлыг ойлгож тэр хоёр найз чигээрээ үлдэж болох л юм.

Тэрээр Федягийн мухлагт очиж түүнээс байр сураглав. Суух хүн нь зургаан настай хүүхэдтэй, үйлэнд сайн авгай бий, айлын эзэгтэй оёдлын машинтай байх хэрэгтэй гэж нэмж өгүүлжээ.

–Тэгвэл түүнийг чинь Лариска дээр оруулчихвал яасан юм бэ? хэмээн Федя санал болгож,

–Ганц бие хүн. Бас машин бий. Шинэ хувцас өмсөх дуртай хэрнээ юм оёж чаддаггүй юм чинь уухайн тас гэртээ оёдолчинтой болно гэсэн үг гэв.

–Тэр авгай хорин рублиэс илүү хөлс төлж чадахгүй шүү.

–Ларискад арван тав ч байсан болно хэмээн Федя гараа савлан,

–Өөрт нь юм оёж өгөх юм бол бүр ч яриа алга. Бас Маруськад ч юмхан оёод өгөх байх гэв.

–Харин Лариска зөвшөөрөх болов уу?

–Намайг хэлбэл зөвшөөрнө.

Хэрэг бүтэх нь тэр. Саша Лидия Григорьевнагийн хоёр чемоданыг Ларискагийн авчирч, оёдлын машиныг нь шалгаж үзээд тосолж өгөв. Хуучин ч гэсэн “Зингер” гэдэг сайн машин аж.

–За, таны үйлс бүтэх болтугай, хэрэг гарвал хэлээрэй... гэж Саша өгүүлэв.

Соловейчик чухам яаж оргосон тухай нарийн ширийн зүйлийг Саша мэдэхсэн гэж хүснэ. Гэвч Лидия Григорьевна юу ч эс ярих бөгөөд түүнийг асууж шалгаах нь Сашад эвгүй байв.

Саша Лидия Григорьевнаг Ларискагийн суулгасныг Всеволод Сергеевич мэдээд хуучин зангаараа инээмсэглэн,

–Завхай эм, гэртээ өтөлсөн бэр хоёрын холбоо үүсжээ. Харин наадах нь хүүхэдтэй болохоор яах ч аргагүй хүн юм. Ингэхэд тэр Тарасик гэж хэн болохыг та мэдэх үү? гэв.

–Ач хүү гэсэн, гэхдээ төсгүй л юм.

–Тэр чинь энд үхсэн тусгай нүүдлийнхэн буюу албан ёсоор бол нударганчууд гэгчийн хүү.

Саша гайхаж хоцров.

–Энэ газар хүүхэд өсгөх гэж аваа юу? Зоримог явдал байна.

Всеволод Сергеевич толгой сэгсрэв.

–Эсвэл амьдралын зорилготой болж, үгүйдээ юухнаас ч гэсэн зуурч авах гэсэн оролдлого биз.

–Ямар ч зорилгын үүднээс тэгсэн бай, энэ хүүхний энэ ажил аргагүй л хүнлэг, ариун сайхан юм. Энэ бол надад найдвар төрүүлж байна. Ийм зэрлэг бүдүүлэг нөхцөлд ч гэсэн хүний эрхэм дээд нандин чанар мандаж байна. Энэрэх сэтгэл бол тэр нандин чанарын нэг гэж Саша хэлэв.

–Манай бодит байдлын эргэж хөрвөх үзэгдлийн тухай би бодож байна гэж Всеволод Сергеевич яриаг тосгуулан авч,

–Лидия Григорьевна тухайн үедээ Тарасикийн эцэг эхийн хөрөнгийг хурааж Сибирьт цөлсөн байхад үгүй гэхийн газар байхгүй. Гэтэл одоо өөрөө Сибирьт ирчихээд нөгөөдүүлийнхээ хүүт хүмүүжүүлж, түүнээс болж өөрөө гачигдал зовлон амсаж байна. Энэ баримт нүглээ наминчлах тухай сэдвийн зүйтэй гэдгийг бататгаж байгаа юм биш биз? гэв.

–Би Христос сүсэгтний сургаалыг муу мэднэ гэж Саша өчөөд,

–Харин Лидия Григорьевнагийн хувьд гэвэл аливаа шашин, үзэл санаанаас урьдаар тэдгээрээс хамаагүй эрхэм чухаг зүйл болсон бусдын төлөө өөрийгөө золионд гаргах сэтгэлдээ хөтлөгдсөн болов уу гэж би бодож байна. Тэгээд энэ нь ийм газар хүртэл илэрч байгаа энэ бүхнээс үүсгэн дахин хэлэхэд, хүнд заяасан хүнлэг чанарыг устгаж чадаагүй, хэзээ ч устгаж чадахгүй юм байна гэсэн найдвар төрж байна гэв.

Саша Лидия Григорьевнад мөнгө зээлүүлбэ гэж хэлэхдээ ердөө гучхан рубльтэй байжээ. Тамхи, керосин хоёр авах хэдэн рубль үлдээгээд өөрөө яаж ийгээд аргаа олно, харин Лидия Григорьевнад ямар ч байсан тус хүргэнэ. Өөрөө бол гэрийнхээ эзэдтэй арван нэгдүгээр сарын сүүлчээр, арга ядвал арван хоёрдугаар сард чаргаар шуудан зөөж эхэлмэгц тооцоо хийчихнэ гэж бодсон хэрэг.

Шуудан түүний баримжаалсанчлан арван хоёрдугаар сарын эхээр ирэв. Бас түүний хүлээж байсан ёсоор мөнгө, Варягийн шугам зургийн үсгээр тодхон хаягласан өвлийн хувцас хунартай илгээмж, ээжийнх нь баахан захидал, бөөн сонин энэ тэр гээд зөндөө юм иржээ. Шуудангийн тамган дээр найм, есдүгээр сар, зарим нэг дээр арван нэгдүгээр сар гэж байх нь зам хаагдахаас өмнө явуулсан захидлууд хойно явуулсантай холилдсон хэрэг бөгөөд ингээд бодоход замд бас нэлээд шуудан явж байгаа гэсэн үг.

Нэг юм уу хоёр долоо хоног жаргалаа дэлгэх болж байна. Естой сайхан арван хоёрдугаар сартай золгох нь энэ.

Саша урьдын адил эхлээд захидлуудаа явуулсан сар өдрөөр нь дараалуулж байгаад гүйлгэж уншив. Ээж нь шинэ сонин юм юу ч бичээгүй байв. Ер нь ч ээжид нь сонин юм гэж юу байх вэ дээ? Нагац эгч нар, Варя энэ тэрээс мэнд уламжилсан боловч эцгийнх нь тухай, Маркийн тухай, найз нөхдийнх нь тухай юу ч алга. Саша өөрөө Варяд захиа бичсэн учраас түүнээс хоёрхон үг ч хамаагүй авах юмсан гэж захидал задлах бүрийдээ дотроо горьдоно. Гэвч захиа болгонд “Варя мэнд дамжуулав”, “Варя мэнд дамжуулав” гэхээс цааш байдаггүй. Боодлуудын хаяг бас Варягийн гарын үсэг байх ажээ.

Тэгээд хамаг горьдлого тасарчихаад сүүлчийнхээ захидлыг задалтал хоёрдугаар хуудасны доод талд Варягийн нэмж бичсэн зүйл байхыг харав.

“Сайн байна уу, Саша! Би одоо ээж дээр чинь ирчихээд бид хоёр чамд захидал бичиж байна. Манайхны ажил явдал, биесүүд цөм сайн байна, ээжийн чинь бие сайн, би Москвагийн зураг төслийн газар ажиллаж байна. Чиний одоо юу хийж байгааг мэдэж болдогсон ч болоосой. Варя”.

Тэрээр эдгээр мөрийн дахин уншив. “Чиний одоо юу хийж байгааг мэдэж болдогсон ч болоосой...” Бурхан минь! Харин түүний өөрийнх нь одоо юу хийж байгааг мэдэж болдогсон ч болоосой, дүрийг нь харж, дууг нь сонсож, биед нь хүрч, нүүрийг нь илбэх юмсан... “Болдогсон ч болоосой... Болдогсон ч болоосой...” гэнэ ээ. Тэр бүсгүйг хайрлан хүсэмжлэх сэтгэл оволзож зүрх нь шимшрэн гөхөлзөөд, Варя гэнэтхэн дэргэд нь хүрээд ирсэн юм шиг санагдаад явчихав...

Зүрх нь булгилан догдлохуйд Саша босон өрөөн дундуураа хэд алхлан биеэ барьж тайвшраад найм, есдүгээр сарын сонинг гүйлгэн харсан боловч сав л хийвэл нөгөө захидлыг барьж авч “Чиний одоо юу хийж байгааг мэдэж болдогсон ч болоосой...” гэсэн мөрийг дахин дахин уншсаар байв.

Амьдрал яагаа ч үгүй байна, чөтгөр чамайг, хамаг амьдрал өмнө минь байна! Түүнд Варя байна, тэрээр одоо энэ тухай баттай мэдэж авлаа. “Чиний одоо юу хийж байгааг мэдэж болдогсон ч болоосой...” Варя байна, ээж нь байна, эргэн тойронд хүмүүс байна, өөрийнх нь бодол санаа байна, тэгэхлээр хүнийг хүн болгож байдаг бүх юм байна.

Жижигхэн дөрвөлжин цонхоор өрөөнд нарны туяа тусжээ. Халуу дүүгтэл гал өрдсөн тул тухлаг дулаахан байлаа. Дажгүй ээ, амьдарч болно! Толгой хоргодох оромжгүй хүмүүнд л хэцүү байгаа.

Үүдний пинд нэг хүн ирж дороо дэвсэлснээ эсгий гутлынхаа цасыг шүүрээр гүвээд хаалга татав. Энэ хүн Всеволод Сергеевич ажээ.

Саша баярлан,

–Наашаа ороод хувцсаа тайл гэв.

Всеволод Сергеевич үстэй дээлээ тайлж малгай, хүзүүнийхээ ороолтыг аваад бээлийгээ пийшин дээр тавив... Бээрсэн гараа хооронд нь үрж өрөөн дундуур хэд алхалснаа ширээ рүү дохиж,

–Шуудангаа янзалж байна уу? гэв.

–Тийм ээ, зөндөө юм авлаа. Та ч бас тэгээ биз дээ?

–Тэгээд сонин юм юу байна даа? гээд Всеволод Сергеевич асуултыг асуултаар хариулав.

–Гойд юм алга... Ээжээс маань, бас найз нөхдөөс маань захидлууд иржээ. Түүнд л баярлаж

байна.

–Тэгэлгүй яахав, тэгэлгүй яахав хэмээн Всеволод Сергеевич Сашагийн үгийг огт сонсохгүй байгаа мэт өчив.

–Та яачихаа вэ? Аль нэг юманд санаа зовоо юу? гэж Саша асуув.

–Хэрэг бишдэж байна, Саша, бишдэж байна гээд Всеволод Сергеевич өрөөн дундуур холхин хоёр гараа үрсээр байв.

Соловейчик... гэсэн бодол хамгийн түрүүнд толгойд харвалаа. Үнэхээр барьчихлаа гэж үү?

–Тийм үү? Ямар гээч юм болчихоо вэ? Всеволод Сергеевич Сашагийн дэргэд зогтусав.

–Арван хоёрдугаар сарын нэгэнд Ленинградд Киров алагдчихжээ.

–Киров? хэмээн Саша балмагдан өгүүлээд,

–Хэн алчихаа вэ? гэж асуув.

–Тодорхой мэдэх юм алга. Засгийн газрын мэдээнд нэвтрүүлснээр бол арван хоёрдугаар сарын нэгний арван зургаан цаг хагаст Ленинград хотноо, Смольныйд ажилчин ангийн дайснуудын явуулсан алуурчын гарт Киров алагджээ. Буудсан этгээд баригдсан. Түүний хэн болохыг тодруулж байгаа гэнэ.

–Танд тэр сонин нь байна уу?

–Надад сонин байхгүй, гэхдээ энэ яг үнэн. Бас хоёр дахь мэдээ байна. Алуурч нь Николаев гэгч нэг хүн гэнэ. Гурав дахь мэдээ бас байна. Аллага хядлагын хэргийг арав хоногийн дотор хөндлөнгийн этгээдийн оролцоогүйгээр, өөрөөр хэлбэл өмгөөлөгчгүйгээр шүүн шийдвэрлэж, шийдвэрийг давж заалдах, өршөөн хэлтрүүлэх ёс байхгүй, ял шийтгэсний дараа нэн даруй буудан алдаг гэнэ. Ийм л байна даа, Саша! “Ажилчин ангийн дайснуудын явуулсан алуурч”, мөн хэлэв ээ бас...

–Энэ үгнээс гойдын юм та юу олов? Юмны учир энэ үгс биш.

–Та тэгж бодож байна уу? гэж Всеволод Сергеевич хариулаад,

–“Ажилчин ангийн дайснуудын явуулсан алуурч” гэсэн хэрнээ яг залгуулаад “Буудсан этгээдийн хэн болохыг тодруулж байгаа” гэсэн байна. Энэ юу гэсэн үг вэ, утга авцалдаа хаа байна? Хэн болох нь мэдэгдээгүй байхад хэн явуулсан нь аль хэзээний тодорхой болчихсон байна... Ойлгогдохгүй байна, ойлгомжгүй байна... Үгүй ээ, тэгж яривал харин ч маш ойлгомжтой байна... гэв.

–Кировыг гойд уран илтгэгч, намын хайр хүлээсэн их сайн хүн байсан гэлцдэг. Хэн түүн рүү гар далайж зүрхлээ вэ?

Всеволод Сергеевич вандан дээр сууж толгойгоо гэдийлгэн хана налав.

–Энэ хэргийг хэн ч хийсэн байлаа гэсэн ёрын муухай цаг ирж байна гэдгийг би танд итгэл төгс хэлж чадна, Саша минь.

1966-1986

Москва

Төгсгөлийн үг

Генерал Максим Иванович Костины командалсан гвардийн буудлагын корпус 1944 оны зургадугаар сарын 20-нд Сарны хотоос баруунтайгуур Рафалувка станцын орчимд хүрэлцэн ирж, Ковелиэс зүүнтэйгүүр ой дотор байрлав.

Шилжин байрлах ажлыг нууцгай хийжээ. Цэргүүд нүдэнд төдийлөн өртөхөөргүй төмөр замын зөрлөг, бяцхан буудлууд дээр галт тэрэгнээс бууцгааж, өөрсдийгөө сайтар өнгөлөн далдлаад ой руу явж орцгоожээ. Генерал Костин гагцхүү шөнийн цагаар нүүж байхыг тушааж гол нуурын усанд орох, юм угаах, радиогоор холбоо барихыг хориглохын хамт аливаа мэдээг шифрлэн нууцалж, утсаар аль болохоор ярихгүй байх тушаал буулгажээ.

Максим Иванович Костин Москвагийн орчимд хороо, Сталинградад дивиз командалж явжээ. Тэгээд Северский Донецэд корпус хүлээн авч, Изюм-Барвенковын зэрэг давшилтын үйл ажиллагаа, Донбассыг чөлөөлөх, Днеприйг гатлах тулалдаан, Ингул, Өмнөд Буг гол дээр болон Одессийг чөлөөлөх тулалдаануудад оролцсон ажээ. Түүний нүүрэн дээр олон хүн, үй олон хүн амь эрсдэж, Максим Иванович хохирлын мэдээг алагдсан, шархадсан, сураггүй алга болсноор нь ангилан гарын үсэг зурна. Хүмүүс, тэдний амьдрал, тэдний үхэл бол дайны эд эсүүд байсан юм. Түүний өгч байсан тушаалууд бас л дайны эд эсүүд, тийм учраас ёсчлон биелэгдэж байжээ. Генералын сайхан сэтгэлийнх нь цаана тавьсан зорилтдоо хүмүүсийг захируулах чадвар, энгийн хээгүй байдлынх нь цаана зоримог, санаанд оромгүй шийдвэр гаргаж чаддаг цэргийн даргын нарийн ухаан, гаднаас нь харахад хүний аясаар юм шиг зангийнх нь цаана албаны харилцааг ухаарах нарийн ойлгоц, хэрэгтэй нөхцөлд ухрах, зайлах чадвар нуугдаж буй бүлгээ. Түүнийг Жуков мэддэг бас үнэлдэг учраас армийнхаа командлалтай харьцахад нь хувийн зарим бэрхшээл учирдаг ч гэсэн өндөр чацтай, өөрийнхөө гучин таван насанд арай ахадмаар нүсэр биетэй энэ залуухан генералын хээгүй зан, цагаан цайлган сэтгэл, түүний хөдвөр хүний гүндүүгүй царай энэ тэр армийн командлагч догшин Чуйковыг хүртэл балмагдуулдаг болой.

Корпус зургадугаар сарын 20-нд хүрэлцэн ирсэн, түүнээс гурав хоногийн дараа, зургадугаар сарын 23-нд Белоруссыг чөлөөлж, улсын хуучин хилийн зааг дээр давшиж хүрэх зорилготой “Багратион” хэмээх байлдааны ажиллагаа эхлэв. Энэ ажиллагаанд 166 дивиз оролцлоо. Гэтэл генерал Костины корпусыг харьяалсан армийг ажиллагаанд оролцуулахгүй байв. Эдний арми арай хожуухан Ковель-Люблины чиглэлээр германы хамгаалалтыг сэт цохиж Баруун Буг гол руу гарах ёстой байсан юмсанж. Энэ давшилтад бэлтгэхэд зориулж сар орчмын хугацаа өгчээ. Цэргийн анги нэгтгэлүүд түрүү түрүүчийн хүнд тулалдаанд хохирол хүлээж, бие бүрэлдэхүүн дутуу болсны гадна эндхийн газар нутгийн төвөгтэй байдлыг бодолцох юм бол нэг сар бол тун давчуу хугацаа.

Генерал Костины корпус үүний урьд өмнө зүгт Украин, Молдавын тал газар байлдааны ажиллагаа явуулж байсан бол энд эрэг татам хавиараа балчигтай өдий төдий гол горхи торлон хэрсэн намагт ойн дундуур давших ёстой байжээ. Цэргүүд зам харгуйд овоолсон саад, нууцалсан миныг арилгах, ухмал нүхнүүдийг тэгшлэх, бага шиг гол усыг гатлах, намаг дээгүүр модон зам дэвсэх, намаг, хүлрийг туулах зэрэг сургууль хийцгээв. Германаас чөлөөлөгдсөн орон нутгийн хүн амаас корпуст дайн байлдааны туршлагагүй олон хүн

нэмэгдэж орж ирсэн тул тэднийг дор хаяхад зэвсэг эзэмших наад захын ажилд сургах хэрэгтэй болжээ.

Максим Иванович дивизүүдийнхээ командын цэг рүү очихдоо эхлээд “виллисээр”, дараа нь мориор явна. Эдний корпусын дивизүүд байрласан газар бол зарим хэсэгтээ нарс, хус, нигүрс, царс ургасан холимог ойтой асар өргөн намаг юм. Намгийн энд тэнд элсэрхэг арлууд байвч тийм арал дээр ухсан газар гэрт ч гэсэн ус тунасан байх тул цэргүүд нарсны мөчир дэвссэн майханд байрласан нь дээр гэж үзнэ. Максим Иванович, гадаа зургадугаар сар болчихсон дулаахан байгаа юм чинь цэргүүд майханд байх нь зүйтэй, бас нойроо сайн авч, гэдэс сайн гарах ёстой хэмээн бодож энэ талаар нарийн шалгаж хянадаг ажээ.

Манай цэргүүд долдугаар сарын 3-нд Минскийг буцаан авч фронтыг 400 км урт зайд сэтлэн тасдаад шуурхай урагшлан давшиж байв. Максим Ивановичийг нэг хорооны командын цэг дээр байхад энэ мэдээ ирсэн тул өөрийнх нь корпусын давших хугацаа өөрчлөгдөж магадгүй гэж санаад байрандаа хуучнаасаа эрт эргэж иржээ. Гэвч армийн штабаас ямар ч шинэ шийдвэр ирсэнгүй. Энэ өдрийн орой ч гэсэн Максим Иванович урьдын адил штабын удирдлагуудыг цуглуулж, илтгэл мэдээллийг сонсохын хамт цэргүүдтэй уулзахад юу санаа зовоож байсан тухай ярьж, үүрэг даалгавар өгч ердийн байдлаар өнгөрөөв.

Максим Иванович цугласан хүмүүсийг шөнө дунд өнгөрч байхад тараагаад кителийнхээ захны товчийг тайлав. Тамхины утаа дүүрчихсэн тул салхи оруулах хэрэгтэй байлаа. Тэрээр өөрөө тамхи татдаггүй ч гэсэн өөрийнхөө хээрийн байранд хүртэл тамхи татахыг хориглож эс чадна. Зөөврийн жижиг мотор байрнаас холгүй жигдхэн нүргэлнэ. Максим Ивановичийг унтахаар хэвгэнгүүт түүнийг унтраана.

–Нөхөр генерал аа, таныг авто үйлчилгээний шинэ дарга хүлээж байна гэж туслах нь илтгэв.

–Яах гэсэн юм бол?

–Хүрэлцэн ирж ажилдаа орсон тухай илтгэх гэнэ.

–Штабын даргад илтгэг.

–Би тэгж хэлсэн чинь танд илтгэнэ гээд байгаа юм.

–За яахав, тэгвэл орог.

Максим Иванович газрын зураг руугаа тонгойв. Давших хугацааг өөрчлөх байх гэсэн бодол толгойд эргэлдээд салж өгдөггүй. Хөдлөх тушаал хэзээ л бол хэзээ ирж мэдэх учраас яг бэлэн байх хэрэгтэй билээ.

Хаалга хяхтнав. Максим Иванович зургаа орхиод эргэж харлаа...

Хээрийн погонтой хуучин ч гэсэн биед нь аятайхан таарсан шинельтэй, саравчтай малгайтай, бэржээнтэн гуталтай офицер үүдэнд зогсож байв. Анивалзсан дэнлүү зураг дэлгэсэн ширээг гэрэлтүүлэхээс цаашгүй байсан тул тэр офицерийн царай харагдсангүй...

Тэглээ ч гэсэн өөрийг нь үүдэнд чимээгүй тэнсэн хүлээж буй хүний төрхнөөс бүүр түүрхэн танил байдал мэдэгдэх шиг болж Максим Ивановичийн дотор хачин оргиод явчих шиг болов...

Сайхь офицер гараа өргөн ёсолж,

–Нөхөр генерал! Гвардийн хошууч Панкратов таны мэдэлд алба хаахаар хүрэлцэн ирлээ гэж тов тодхон илтгэв. Гараа буулгаад “номхон” чигээрээ зогсоно.

Арай ч үгүй байлгүй. Нээрэн гэж үү?

–Алив томилолт оо! гэж Костин гэнэт сөөнгөтсөн дуугаар өгүүлэв.

Офицер цүнхэн дотроосоо томилолтоо гаргаж урагш нэгэнтээ алхаад Максим Иванович руу сарвайв.

Гэтэл генерал ширээ рүүгээ эргэж, эргүүлгэн хүрдэн дээгүүрх гэрлийн утаснаас татахад чийдэн дээшилж байрыг бүрэн гэрэлтүүлсэнд тэрээр офицер луу дахин эргэж харвал Саша мөн гэдэг нь эргэлзээгүй болов!

Максим Иванович томилолтыг авлаа... Нээрэн, яг мөн, Панкратов Александр Павлович...

Тэрээр офицер луу хараагаа шилжүүлэв... өөдөөс нь өөрийнх нь хүүхэд ахуй нас, идэр залуу үе, өөрийнх нь Арбат ширтэж байх шиг... Чингэвээс Максим Иванович биеэ барьж чадалгүй өөрийн эрхгүй,

–Саша, чи юу? гэж хоолой нь чичрэн асуулаа.

–Би гэж офицер хариулав.

Саша... Амьд явна... Хаанаас гараад ирэв ээ? Яаж? Ямар замаар?

Максим Иванович дайныг давж байгаа төдийгүй дайны өмнөх жилүүд, 37, 38, 39 оныг туулан өнгөрүүлсэн юм. Испани, Хасан нуур, Халх голын тулалдаанд шалгарсан цэргийн сайн дарга нар, үнэнч нөхдийг нь түүний нүүрэн дээр баривчилж ард түмний дайсан гэж зарлаж байсан билээ. Тэд нар нь үнэхээрийн дайсан байсан уу? Тэрээр энэ бүхнийг үнэмшихийг хүсээгүй, хэдий ч үнэмшихгүй байж чадсангүй, эсвээс амьдралаа зориулсан ажил үйлсдээ зүтгэх аргагүй болохсон билээ. Энэ тухай бодохгүй байх нь л хамгийн зүйтэй байсан. Тэдгээр хүмүүс арилан үгүй болж, өөрийнх нь үл мэдэх хэн ч буцаж ирдэггүй өөр ертөнц рүү халин одсон.

Гэтэл тэр ертөнцөөс Саша гараад ирлээ. Арван жилийн дараа шүү! Яаж энэ олон жилийг өнгөрөөв? Яаж амьд үлдэв? Ямар учраас чухам өөр лүү нь, өөрийнх нь корпуст түүнийг томилов? Үүний цаана юу байна вэ? Таньснаа дэмий л мэдэгдчихлээ, нэрээр нь шал дэмий дуудчихлаа...

Офицер дахин гараа ёсолж,

–Нөхөр генералд илтгэж болох уу? гэв.

Үгээ тов тодхон хэлж байна... Дуу нь мөн дөө, Сашкагийн дуу... Тэглээ ч гэсэн, тэгсэн ч гэсэн...

–Сул зогс! Илтгэж болно. Саша гараа буулгав.

–Нөхөр генерал! Бүх юм тодорхой байсан нь дээр биз. Би 58 дугаар зүйлээр шийтгүүлсэн хүн, миний хувийн хэрэгт тэмдэглээстэй байгаа. Танай корпус ирье гэж би гуйгаагүй. Би тан руу ирэх дургүй байсан юм. Гэтэл тушаал бол тушаал. Тайлбар тавих юм огт олдоогүй. Бид хуучин танил гэж цорын ганцхан юм хэлбэл хэлэх л байсан. Гэвч удирдлага тийм шалтгийг юу гэж тоох вэ дээ. Харин миний улыг шагайж явах ёстой хүмүүс тэр тухай анаад авах байсан юм. Тэгсэн бол танд төвөг удаж мэдэх шүү дээ. Тийм учраас намайг фронтын штабт буцаахыг хүсье. Би бол хошууч, гэтэл энэ ажил хурандаагийн албан тушаал юм байна, энэ бол үнэмшилтэй шалтгаан. Ингэж шийдвэл та бид хоёрын хэн хэнд нь хамгийн зүйтэй болох байх.

Максим Иванович дуугарсангүй. Тэнгэр минь! Энэ чинь өөрийнх нь хайрлаж явсан нөгөө хуучин Сашка мөн байна. Сашка шулуун шударга зарчимч хүн болохоор хүнд гай болохгүй хэмээн бүх юмыг өөрөө л үүрсээр явна. Бодоход ямар л өөдтэй амьдрал үзээж дээ, гэтэл яг хэвээрээ, яг хуучнаараа байж байна! Максим Иванович руу өөрийнх нь ил цагаан, эрэмгийн зоримог, аргалах зохицохыг үл мэдэх идэр залуу нас нь дахиад ширтэн байна. Ийнхүү дүрэлзэн ассан дурсамжийн дотроос хуучин Макс агсан өөрийгөө бас олж үзээд, цаг самуун жилүүдэд бий болсон нэгэн совиндоо дөрлөгдөн шолбойж, өөрөө жинхэнэ хэн билээ гэдгээ умартан хэдэн хормын зайд арчаагүй байдалд орж муу юм бодсондоо ичиж орхив.

–Нөхөр генерал, явж болох уу?

–Аль вэ Саша, хувцсаа тайл, уулзан золгосны хундага тулгая гэж Максим Иванович хэлэв.

–Максим, чухам энэ учраас л би чам руу ирэх дургүй байсан юм, би чамайгаа эрхиш мэдэлгүй яахав дээ гэж Саша үнэн санаанаасаа өгүүлэв.

...Максим Ивановичийн хоолой зангирч шүүрс алдаад Сашагийн мөрөн дээр гараа тавьж,

–Баярлалаа, Саша... Миний тухай тэгж бодож яваад чинь баярлалаа. За тэр яахав, суу! гэв.

Тэгснээ Сашаг орхин үүд рүү түргэн очиж хаалга нээгээд,

–Бидэнд хоёр аяга юм, зууш, цай бэлтгээд орхи гэж туслахдаа тушаав.

–Максим хэмээн Саша дахин өгүүлтэл Максим Иванович,

–Больж үз! хэмээн түүний үгийг таслаад,

–Энүүхэндээ бол албан тушаалаар ч, цол хэргэмээр ч би ахмад нь шүү гэв.

Миний хоёр баатрын уулзалтыг би ингэж төсөөлж байна. Гэхдээ сайхь зураг хожим яг энэ байдлаараа үлдэх эсэхийг би мэдэхгүй. Романы баатрууд өөрийн өөрийнхөө амьдралаар замнах чадвартай байдаг болохоор түүнийг зөвхөн тэмдэглэн буулгахаас өөр юм зохиолч хүнд эс үлдэх бөлгөө. Дараачийнхаа романыг бичиж амжих уу, үгүй юу гэдгээ би бас мэдэхгүй байна. Хувь заяа минь надад дахиад хэдэн жилийн нас хайрлавал би үргэлжлүүлэн хүүрнэж, ямар ч гэм буруугүй мянга мянган хүнийг аж төрөлд нь эгүүлэн оруулж, тэгэх боломжгүй нэгэнт төрөл арилжсан хүмүүсийн ариун шударга нэрийг сэргээн тогтоосон 1956 он, Хорьдугаар их хурлыг хүртэл хуучлахаар найдаж байнам.

ДЭД БОТЬ

АЙДАС

Нэгдүгээр хэсэг

1

Шуудан ирэх ёстой өдрөө ирсэнгүй. Дараачийн долоо хоногт ч бас таг чиг. Гэхдээ Кежмийн өртөөний чарга худалдагч Федькагийн мухлагт ирдгээрээ ирж, юу хээ авчирсаар байлаа.

Саша мухлагт очив. Федя хаалгаа тайлахгүй байсан чинь агуулахаар дамжин ордог арынхаа хаалгаар оруулж байсан юмсанж.

-Чамд бараа ирээ юү?

-Юухан хээхэн ирсээн.

-Тэгвэл яагаад шуудан алга байна, мэдээгүй биз?

-хэн мэдлээ. Чи юм хэрэгтэй бол тэмдэглүүлчихээд зээлээр авч байх юм уу?

-Баярлалаа, надад юу ч хэрэггүй.

Саша Всеволод Сергеевич рүү бас очив. Цаадах нь гэрийн эзний бүсэлхийгээрээ хуниас бүхий урт хормойтой нэхий дээлийг нөмрөөд орон дээр хэвтэж байж.

-Та аягүйрхээ юү?

-Үгүй ээ, зүгээр.

-Тэгвэл яагаад хэвтэж байгаа билээ?

-Өөр яахсан билээ?

-Шуудан яагаад ирэхгүй байна аа?

-Шуудан уу? Шуудан ирүүлмээр байна уу? Танд одоо арай өөр шуудан авчирч өгөх байлгүй.

-Ойлгосонгүй.

-Ойлгосонгүй гэнэ ээ... Тэгвэл улс оронд маань юу болж байгааг ойлгож байна уу? Нөхөр Кировыг ажилчин ангийн дайсан алчихаад байна, гэтэл та тэр дайсанд захиа сэлтийг нь цаг хугацаанд нь хүр-гүүлж байх санаатай байх нь ээ. Саша, та юу бодож байна аа?! Засаг төр чинь бэлтгэх ёстой, хариу цохилт хийхээр бэлтгэх ёстой шүү дээ. Орос орон тэр аяараа доргих цохилт шүү. Ажилчин ангийн жолоодогчийг алах дурыг нэгмөсөн тонилгож, ажилчин ангийн дайснууд элдэв нууц яргачдыг дахиад хэзээ ч явуулахгүй болгох цохилт. Харин тэр ажилчин ангийн дайснууд гэж хэн болох, яргачид гэж бас хэн болохыг одоо хэр тодруулж байгаа л даа. Гэтэл та гэдэг хүн яана гэнэ ээ, яргачид, тэдний удирдагчид хэн болохыг бүх нийтээрээ тодруулж байгаа энэ үед, бас аюумшигт хариу цохилтыг бэлтгэж байгаа энэ үед

захиа зангаа үгүйлж, сонин хэвлэлээ саначихаж гэнэ үү. Ажилчин ангийн дайснуудад ямар юмных нь захиа байх юм бэ? хүн алсныхаа ялнаас яаж мултрах тухай хэл амаа ололцог гэж захиа бичилцүүлэх үү? Юун сонин хэвлэл вэ? Хэрэг явдлын байр байдлыг баримжаалж ая эвээ олог гэж хэвлэл уншуулах уу? Үгүй шүү, хонгор минь, танд тийм боломж олгохгүй. Харин таныг элдвээр оролдохгүй, энэ хар хүйтэнд Красноярск руу явган нүцгэн хөөхгүй байгаа нь их юм, башийлаа гэж хэлэх вий нэг.

-За, за хэмээн Саша инээд алдаж, -Намайг айлгах гээд яахав, гэхдээ надаас урьдаар өөрийгөө бүү айлга гэв.

Всеволод Сергеевич өндийж орон дээрээ сандайлаад Саша руу эгцлэн харав.

-Би таныг айлгаж байна ий? Харин ч болвоос тайвшруулж байна. Та Каюровыг харсаар удаж байна уу?

-Каюровыг уу? Хэд хоногийн өмнө гудамжинд тааралдсан.

-Дахиад тааралдах нь өнгөрсөн.

Саша гайхшран харахад Всеволод Сергеевич,

-Харин тийм гэм, урьд шөнө нэг чарга хүрч ирээд муусайн юмыг нь хайш яайш ачсан болоод түүнийг аваад явчихсан гэв.

-Ийм юм харсан хүн байхгүй гэж Саша балмагдан өгүүлэв.

-Харин тийм ээ. Ноход хүртэл ганц гав хийгээгүй. Цөм дуг нойрондоо байсан хэрэг. Ийм л байна шүү дээ. Нөгөө тантай цуг явсан Володя Квачазег санаж байна уу?

-Саналгүй яахав.

-Тэгвэл түүнийг чинь харгалзагчтайгаар Красноярск руу өртөөлөн хүргэж өгсөн. Бас Ангар, Чунад байсан түүний нэг санаатнуудыг цөмийг хүргэсэн. Гольтявиногийнхнийг бас цөмийг нь. Та санаж байгаа шүү дээ, эсер асан Мария Федоровна, анархист асан Анатолий Георгиевич, нөгөө хөөрхөн бүсгүй... Фрида энэ тэрийг цөмийг нь хүргүүлсэн. Бүгдийг нь түүж цуглуулж байна. Удахгүй та бидний ээлж ирнэ. Таныг Кежмад байхад Елизавета Петровна Самсонова гэдэг цөллөгний авгай тааралдаж байгаагүй биз?

-Тааралдаж байсан, би танина.

Саша тэр авгайд Мария Федоровнагаас өгүүлсэн хорин таван рублийг дамжуулж байсан билээ.

-Тэгвэл тэр авгайгий чинь бас туугаад явчихсан, гэтэл мань хүн далан хоёртой шүү дээ.

Саша дал мөрөө хавчисхийн,

-Володя, Фрида, бид мэтийн залуусыг, тэр ч байтугай таныг хорих газар руу илгээхийг би ойлгож байна. Ямар ч атугай үнэ хөлсгүй ажлын хүч. Харин далан хоёртой чавганцаар яана бол доо, Красноярск ч хүрч чадахгүй замдаа мажийчихна гэв.

-Тэгээд юу гэж? Тэр ямар хамаа байна, хэний санаа зовох сон билээ? Саша, чин үнэнийг хэлэхэд та надад гайхаш төрүүлж байна. Тийм тийм зүйл анги, тийм тийм хугацаатай цөллөгийнхнийг Красноярскт яаралтай хүргэж өг гээд тодорхой шийдвэр гарчихсан байг. Тэгвэл орон нутагт энэ шийдвэрийг биелүүлэх хүн, өөрөөр хэлбэл, аль нэгэн бүрэн эрхт төлөөлөгч цөллөгийн хүнийг настай юм, өвчтэй юм, хөөрхий зайлуул... гэхчилэн элдвийг эрэгцүүлнэ гэж та бодож байна уу? Тэгсэн хүнийг чинь тушаал биелүүлсэнгүй гээд сум зоочихно чухам. Харин явуулчихваас тушаал биелүүлчих нь тэр. Замдаа өөд болчихвол тэр явдал мань хүнд падгүй, тэглээ гэж өөрт нь хариуцлага оногдохгүй. Харин Красноярскт амьд залгуулчихвал дахиад таван жил хорих шинэ ял нэмж өгөөд нэг тийш нь явуулчихна, очих газар нь хүргэж чадвал чадах нь тэр, чадахгүй бол данснаас хасчихна. Тайлан тооцооны дүн мөргөж байвал ёсоор байгаа нь тэр. Нэрсийн жагсаалтад байгаа бол амьд, үхсэн нь хамаа байхгүй, байна л гэсэн үг. Үхвэл жагсаалтад тэмдэг тавиад л нийт дүнгээс хасчихна, хамаг тооны ухаан тэгээд л гүйцээ. Тэгэхээр Саша, та бол цөөхөн жилтэй хүн, танд ямар байхыг бүү мэд, Михаил Михайлович бид хоёр шиг нөгөөдүүлийн номоор давтан хэрэгтнүүд гэгддэг хүмүүст бол “товлосон хугацаандаа” гэж дуунд байдаг шиг л юм болно.

-За яахав, хүлээгээд л байцгааж байя гэж Саша тайван хэллээ.

Тэд нар хорвоогийн хязгаарт Мозгово гацаандаа тийнхүү хоног төөрүүлсээр байв. Хэдийвээр орчлонгоос тасархай ч гэсэн ертөнцөд ямар нэгэн аюумшигт явдал болсоор бөгөөд удахгүй өөрсдийг нь шүргэх ёстой, гарцаагүй шүргэнэ гэдгийг мэдрэн буй билээ.

Саша Зидатай бараг тааралдахаа больжээ. Кежмад хоёр эмэгтэй багшийг ажлаас халав. Нэгнийх нь нөхөр цөллөгний хүн, нөгөө нь өөрөө урьд цөллөгт байгаад хугацаа дууссаны дараа Кежмад суурьшсан аж. Уул нь энэ бүхэн хуучин илэрхий зүйл атал одоо Кировыг алснаас хойш шинэ цаг ирж, улс орныг “эргэлзээтэй этгээдүүд”-ээс цэвэрлэж эхэлсэн тул тэр хоёр багшийг халж оронд нь Зидаг тавьжээ. Тэрээр өглөөний долоогоос арав хүртэл Мозговод хичээл заачихаад, арван цагт сургууль дээр ирдэг чаргаар Кежма руу явж, үдэш орой болсон хойно хүргүүлж ирнэ. Гэвч Саша түүнтэй нэг удаа гадаа тааралдахдаа саатан зогтусч мэнд мэдэхийн ялдамд ажил явдлынх нь тухай найр тавин асууж сонирхов. Зида хараа буруулан байж, ажил ихтэйг эс тооцвол юм бүхэн сайн сайхан буй хэмээжээ.

-Зида, тэгэхэд миний буруу байсан шүү, чамайг дэмий гомдоо-сон, тэгж гомдоосондоо их харамсаж яваа. Болж өгвөл намайг уучилж өршөөгөөрэй гэж Сашаг өчихөд бүсгүй сая нэг өөдөөс нь эгцлэн харж,

-Яахав дээ, Саша, болдог юм болоод өнгөрсөн шүү дээ гэв.

-Болоод өнгөрснийг би ойлгож байна. Нэгэнт эвдэрснийг буцааж наахын аргагүй гэдгийг ч бас ойлгож байна. Гэхдээ хоюулаа найз нөхөд хэвээр баймаар байна.

-Тэгэлгүй яахав, тэгэлгүйдээ ер хэмээн Зида инээмсэглэв.

Сайхь яриа үүгээр дуусчээ.

Тэр хоёр түүнээс хойш дахиж тааралдсангүй. Учир юун гэвэл Зида Мозгово, Кежма хоёрын дунд холхиод завгүй, Саша ч ажил олж авчээ.

1935 оны нэгдүгээр сарын хүйтнийг хэлээд яахав. Ангарын хөгшчүүл урьд хожид хэзээ ингэж жаварлаж байсныг бодоод бодоод олдоггүй. Дэмий л орон гэртээ хоргодоцгоон “Өвөл биш ёстой хүйтэн там гэгч байна даа” гэгцгээнэ.

Хамтралын дарга Иван Парфеновичийн хөөцөлдөх ажил мундахгүй олон. Хэдхэн жилийн өмнө хоёр мянган үхэртэй байсан тосгонд одоохондоо айлуудын малын хашаа хороо хэвээр, хамтралд авгай хүүхнүүд хүртэмжтэй, тэдний мал ахуйгаа адуулж арчлах дадал заншлыг хараахан хөнөөчихөөгүй болохоор хоёр зуун үхэрт эзэн олгоод хуваарилчих бол хэцүү ажил биш.

Гэхдээ хэдэн арван айлаар тараагаад өгчихсөн нийт сүргийнхээ байдлыг хараандаа байлгахад тийм ч амаргүй. Үнээний олонхи нь хээлтэй, тэгэхээр хоол тэжээлийг хянуур өгөх хэрэгтэй, Ангарын харзнаас зөөдөг уснаас бүлээсгэж хоногтоо гурваас доошгүй услана, хэвтрийг нь байнга хуурайлж цэвэрлэнэ, өдөрт үгүйдээн хоёр, гурван цаг бэлчээнэ, өвтгөх өөдөхөөс хамгаална, төллөөд эхлэхийн үед тусгай байранд шилжүүлнэ. Ийм ном заавартай. Бас дааруулж бээрүүлчихгүйн тулд салхи савираас хамгаалах хэрэгтэй, гэтэл хашаа саравч гэж хариугүй, арга ч үгүй юм биз дээ, малгүй хойно хашааг хэн тордох билээ.

Хамтрал саалийн ферм буюу хар үгээр хэлбэл үнээний хоёр эгнээ зээлтэй том байр барина хэмээсээр гурван жилийн нүүр үзэж байна. Гэвч аль нэг садаа мундахгүй тул ажил урагшаа ахидаггүй.

Районьхон саалийн ферм барьж байгаа тухай тайлан гаргах юм болсон чинь нэг ч баригдаж байгаа ферм байдаггүй гэнэ... Аминыхаа хашаа хороогоор болгоод байгаа юм санж. Дарга нар, мэдээж, бүр балмагдаж хоцорч. Хязгаарын төв рүү тийм тайлан явуулах юм бол мал аж ахуйн хөгжлийг тасалдуулсан хэргээр шүүхэд татагдана гэсэн үг, аягүй бол хорлон сүйтгэсэн хэрэг гэж үзээд буудан өгөхийг ч байг гэх газаргүй. Хэрэг ингэж бишдсэн учраас хавар гэхэд, үнээ ид тугалж эхлэхээс өмнө ямар ч байсан саалийн фермийг барьж дуусгах тушаал буулгажээ.

Иван Парфенович бригад зохион байгуулж, ахлагчаар нь хуучин цагийн сайн мужаан хэмээн Сашагийн суудаг айлын эзэн Савва Лукичийг тавьжээ. Уул нь ч тосгоны эр хүйстэй болгон мужаан л даа.

-Чи надад хань болох юм биш үү? Хөдөлмөр өдрийнх нь тооцоог над дээр гаргачихна, хөлсийг нь би чамд өгчихнө гэж Савва Лукич Сашад хэлжээ.

-Иван Парфенович юу гэх бол?

-Харин тэр л тэгж хэлсэн юм гэж Савва Лукич хэнэггүй өчив.

Саша тийнхүү мужигнах болов.

Тэдний бригад зургаан хүнтэй. Савва Лукич, Саша хоёроос гадна дөрвөн эр. мань хүн гуалин цавчив. Хөндөл дээр тавьж хажуу талаас нь соёо төмрөөр бэхлэнэ. Нэг хагадасыг сайн түлж нүүрсжүүлж байгаад утсаа нүүрсдэж түүгээрээ гуалин дээр у т а с тавьж тэр дагуугаа сүхээр цавчина.

Нэг талынх нь цавчаасны өргөн хорин таван сантиметр байхаар хоёр хацар гаргаж цавчихаад нөгөөдүүлийгээ дуудаж, гуалингаа эргүүлж бэхлээд дахиад хоёр хацар гарган цавчихуйд дөрвөн хацар үүсч өнцөгнүүдийг дарваас сая дүнз бэлэн болох нь тэр.

Савва Лукич дүнзийг тойрч харчихаад,

-Чи гуалин цавчина аа, болох юм байна гэхэд нөгөө харчуул нь,

-Залуу хүн гэсэндээ засаа нь цэвэрхэн байна хэмээн хээгүй инээлдэцгээв.

Савва Лукич нэг дүнзний үзүүрт углуурга гаргав. Саша дуурайгаад хийсэн чинь бас л болоод явчихлаа. Жавар хүчтэй хайрч байлаа ч гэсэн ажиллахад цаанаа л нэг аятайхан. Гуалингийн хажуугаар цавчдас бутран унаж модны шинэхэн үнэр жавартай хослон хамар цоргино.

Харчуул бул хад гэмээр том том чулуу ачиж авчирна. Энд хүйтэн учраас байшингийн суурь хийх гэж газар ухахгүй, чулуун дээр шууд яс модоо тавьчихна. Завсар зайг нь нимгэн банзаар таглаж юмаар дүүргээд дахиад банзаар хуччихна.

Саша дээд доод яс модны дүнз цавчиж бэлтгэхээс гадна өөр нэг хүнтэй хоёр хоёр метрээр мод тайрч, түүн дээрээ хөвд чигжих гурив гаргана.

-Хөвд, шаантаг хоёр байдаггүйсэн бол хөөрхий мужаан гуай мажийх билээ хэмээн Савва Лукич алиална.

Тэрээр гэр орондоо байхдаа үг дуу цөөнтэй, голдуу гадаа ямар нэг юм хийж оролдсон шиг байдаг ахул ажил дээрээ болохоор дуу шуутай, бүр алиалах санаатай.

Бусад хэд нь нимгэн, зузаан банз цавчих буюу зүснэ. Зүсэх болвол нэг нь дээр нь, нөгөө нь доор нь зогсож байгаад түлээний хөрөөгөөр хөрөөднө. Уур уцааргүй урамтай ажиллацгаана. хэн нэг нь хөрөөгөө далиу бариад банзаа эвдчихсэн ч гэсэн хараал зүхэл тавилгүй дахиад засаад хийчихнэ. Хадаас юм уу, углуурга руу хэн нэг нь онож цохиогүй бол,

-Авгайнхдаа бол арай ингэж зөрүүлддэггүй байлгүй гэж тохуурхацгаана.

Саша одоо эрт унтаж, өглөө өвгөний хамт үүрээр босдог болжээ. Эмгэн нь өглөөний унд хэдийн бэлдчихсэн байх тул мань хоёр идэж уучихаад ажилдаа яваад өгнө.

Оройн цагаар Всеволод Сергеевич хаа нэгтээ орж ирнэ.

Тэрээр сэргэлэн байх гэж хичээвч цаанаа л нэг царай алдсан нь илт. Тэднийд нэг эрт өтлөсөн

туранхай авгай Кежмаас ирдэг бөгөөд мань Всеволод Сергеевич түүнийг зочлох гэж хөл алдана.

Гэтэл нэг удаа Всеволод Сергеевич үнээний байр руу өдөр хүрээд ирэв. түүнийг өвгөн түрүүлж хараад,

-Саня, чам руу хүн ирж явна гэв.

Юу гэгч болоо юм бол?

Всеволод Сергеевич нэг боодолтой юмаар даллаж,

-Шуудан иржээ! Би таны захидал, сонингуудыг аваад ирлээ хэмээв.

-Всеволод Сергеевич минь, баярлалаа, юун сайн юм бэ!

Саша захидлуудаа авангуут өвөл ажил хийхэд тохирсон бугын арьсан бээлий, түүний дотуур өмсдөг ноосон бээлий энэ тэрээ суга татаад, нэг дугтуйг урж захидлын сар өдрийг харснаа, Варягийн зурвас дандаа эцэст нь байдаг болохоор тэр даруй хуудсыг эргүүлэв. Энэ захидалд Варягаас юу ч байсангүй. Хоёрдахь дугтуйг урж үзвэл дахиад алга.

Гуравдахь нь. Байж байна шүү!

Тэрээр Варягийн бичгийг харах төдийд л баяр хөөрөөр бялхаад ирдэг билээ.

Варя товчхон бичжээ: “Надаар сонин юмгүй. Аж төрж байна, ажлаа хийж байна... санаж байна. Бид чамайг хүлээсээр сууна”.

Бүсгүй түүнд илээр өөр юу бичиж чадахсан билээ? Юу ч чадахгүй... Яг л өөрөө түүнд бичиж чаддаггүйн адил. Гэхдээ мань хүнд энэ хэдэн үг л болоод явчих нь тэр. Тэрээр өөрийг нь хүлээж байгаа нь л гол юм, бас энэ хараал идсэн Мозговод хоёрхон жил хүрэхгүй ёрдойж байх хугацаа үлдээд байгаа нь гол зүйл. Энэ л гол зүйл шүү дээ! Үүний дараа Москвад суух бололцоо олдсон ч, эс олдсон ч тэр хоёр уулзахдаа л нэг уулзана.

Саша малилзан байж хоёр халаасандаа захидлуудаа хувааж хийв. Баруун талынхдаа Варягийн зурвасгүйг, зүүн талынхдаа зурвастайг хийлээ.

-Всеволод Сергеевич, та манайд очоод сонин харзнаж бай, бид нар мөдхөн харина.

Савва Лукич тамхиа ороож,

-Юу болоод захиануудаа далд хийчихэв? Унш, унш гэв. Цагаан цайлган сэтгэлтэй, ёстой алт шиг өвгөн шүү. Саша,

-Дараа уншина аа гэв.

Бүрий бууж эхэлсэн тул ажлаа дуусгаж, багаж сэлтээ хайрцаглаад гуалингуудын завсраар

нуув.

Гэртээ иртэл Всеволод Сергеевич Сашад нэг сонин өглөө.

-Унш даа!

-За, байзнаарай, үгүйдээн хувцсаа тайлаад орхъё.

Саша тоодон дээл, малгай хоёроо тайлан, бугын арьсан бээлий, дотуур ноосон бээлийгээ пийшин дээр тавиад гутлаа сольсны дараа сая сонинг авлаа.

Кировыг алсны яг дараагаар нийтлэсэн ЗСБНХУ-ын Төвийн Гүйцэтгэх Хорооны алан хядлагын тухай тогтоолд ингэж өгүүлжээ:

“Зөвлөлт засгийн ажилтнуудын эсрэг үйлдсэн алан хядах үйлдэл болон алан хядах байгууллагуудын хэргийг мөрдөн байцаах, хянан шийтгэх тухай Холбооны бүгд найрамдах улсуудад мөрдөж байгаа эрүүгийн байцаан шийтгэх хуулинд дараахь өөрчлөлтүүдийг оруулсугай. Үүнд:

1. Ийм хэргийг мөрдөх ажлыг арваас илүүгүй хоногийн хугацаанд дуусгаж байх.
2. Ялын төлөвлөгөөг шүүн таслах хурлаас нэг хоногийн өмнө яллагдагчид гардуулж байх.
3. Шүүх хурлыг холбогдох талуудыг оролцуулахгүй хийж байх.
4. Ялыг давж заалдах буюу өршөөл үзүүлэх хүсэлт гаргахыг хориглох.
5. Дээд хэмжээгээр авах ялыг нэн даруй ёсоор болгож байх”.

-Үгүй ер, мөн дөө хэмээн Саша бодлогошрон өгүүлэхэд Всеволод Сергеевич,

-Энэ бол дайны цагийн хууль байна, гэтэл одоо чинь дайн болоогүй байгаа биз дээ. Ямар ч төр, ямар ч засаг яллагдагчийн өмгөөлүүлэх эрхийг хасах ёсгүй, гэтэл энэ тогтоол шүүгдэгч өмгөөлөгч авах боломжийг хааж байгаа төдийгүй ялынх нь төлөвлөгөөг ганц хоногийн өмнө өөрт нь өгч байгаа юм чинь өмөөрөх бэлтгэлээ хийж амжихгүй учраас өөрийгөө өмгөөлөх ч бололцоо олгохгүй байна. Яллагдагчийн давж заалдах эрхийг хэн ч хасах ёсгүй, шүүгч гэдэг чинь адилхан л хүн шүү дээ, тэднийг алдаа хийхийг хэн байг гэхэв. Энэрэл нигүүсэл байхгүйгээр ямар ч төр улс оршин тогтнож чадахгүй, тэгэхээр яллагдагчийн өршөөл үзэх горьдлогыг хэн ч боогдуулах эрх байхгүй. Энэ тогтоолд хүний амь хөнөөсөн хэргийн тухай биш, Зөвлөлт засгийн ажилтны эсрэг өдүүлсэн алан хядах явдлын тухай ерөнхий зүйл зааж байгаа учраас дайны цагийн хуулиас ч доор юм. Алан хядах явдал гэдэг чинь тун задгай ойлголт, Саша минь. Юуг ч энүүнд хамааруулж болно. Зөвлөлт засгийн ажилтан гэдэгт Сталинаас авахуулаад тариачин хүний хөдөлмөр өдрийг будлиулснаас болж түүнд зүхүүлж зануулсан хамтралын тоо бүртгэгч хүртэл хэн дуртай хүнийг тооцож болно. Энэ бол өмгөөлөл ивээлгүй, гэм зэмгүй хүмүүсийг хараа хяналтгүй устгах тухай тогтоол байна. Энэ бол хууль ёсыг үй олноор завхруулах тухай хууль гээд толгой сэгсрэв.

-Пушкин “Амьгүй албат”-ын эхний хэдэн бүлгийг сонсоод Гогольд юу гэж хэлснийг санаж байна уу? “Бурхан минь, манай Орос чинь яасан гунигтай юм бэ” гэсэн. Тэгвэл ийм тогтоолын тухай юу хэлж болох байна? “Хөөрхий зовлонт Орос” гэх үү?! Бас тэр шуурхайлсныг нь хараач. Кировыг арван хоёрдугаар сарын нэгэнд алсан, гэтэл тэр дор нь шинэ хууль бэлэн болоод нийтлэгдчихсэн байна. Энэ танд ямар байна, аан?

-Всеволод Сергеевич, би танд өөрийнхөө мөрдөн байцаагчийн тухай яриагүй. Овог нь Дьяков гэдэг юм. Нүдний шилтэй яхир амьтан. Мөн ховорхон чөтгөр дөө. Надад хэрэг тулгалаа. Тэгээд байцаалтынх нь тэмдэглэлд гарын үсэг зурахгүй болохоор гоморхож, “Та намын өмнө гэмээ хүлээе гэхгүй байна” гэж цухалдаж дүрэмдэнэ. Муу сүг! Яагаад тэр санаанд ороод ирэв гээч? Нээрэн... Ийм тогтоол жил хагасын өмнө гарсан байлаа гэхэд тэр этгээд намайг алан хядлагын хэргээр яллаж чадах байсан шүү. Учрыг авцалдуулж цөхөхгүй. Та яагаад баярын ханын сонинд нөхөр Сталины нэрийг дурдсангүй вэ? Яагаад гэвэл та нөхөр Сталины эсрэг байна. Улс орон, намыг түүгээр удирдуулахыг та хүсэхгүй байна. Тэгэхээр та түүнийг яаж зайлуулж чадах вэ? Гагцхүү түүнийг алж л зайлуулна. Нөхөр Сталиныг, манай эцэг, их багш, манай жолоодогч Сталиныг шүү. Өө, та ийм юм хэзээ ч ярьж байгаагүй юу? Мэдээж шүү дээ, ийм юмыг задгай ярих ном байхгүй. Гэхдээ та дотроо ийм санаа а г у у л ж явсан, ая эв нь таарсан цагт хэрэгжүүлэх л байсан. Та бол нуугдмал алан хядагч, таны найз нар нуугдмал алан хядагчид, та нар цөмөөрөө нийлээд алан хядах байгууллага. Тэгэхээр өмгөөлөгчгүй шүүх хурал, давж заалдах эрхгүй ял, шүүх хурлаас хойш нэг цагийн дараа буудан.

-Ээ бас, ингэж ярихдаа хүрвэл ч таны аз дайрчээ хэмээн Всеволод Сергеевич толгой дохиод Саша мушилзаж,

-Тэгвэл би азтай хүн болж таарах нь ээ. Ийм учралыг бодож юм амсвал ямар вэ? гэв.

-Дургүйцэхгүй шүү. Харин та яагаад үнэхээр азтай хүн бэ гэдгийг би тайлбарлаж өгнө өө.

Сашад жаахан спирт байжээ. Гэрийн эзэгтэй утмал хадран загас хэрчилж, юу юугүй тогоо шанага боллоо.

Саша захидлуудаа дахин дахин уншиж, Всеволод Сергеевич сонин гүйлгэж суулаа.

-Юу гээч болж байна даа, Саша... Хаа сайгүй шүүн таслах хурал хийж, үй олноор нь буудан хороож байна. Ленинградаас мянга мянган язгууртан, хуучин хөрөнгөтнийг хөөж байна, язгууртан, хөрөнгөтөн явсан хүмүүсийн хүүхдүүдийг хөөж байна, тэднийг яалаа гэж тэр вэ? Гэтэл ард түмэн яаж байна?! Ард түмэн ам хамхиад сууж байна уу? Хаанаас даа?! Ард түмэн амаа хамхиагүй, дуугаа хураагаагүй, үгүй чиш! Та үз, унш, ард түмэн гэсгээн цээрлүүлэхийг шаардаж байна. Владивостокоос Одесса хүртэл бүх орон даяар хурал цуглаан болж, илчил!, устга!, бууд! хэмээн шаардаж байна. Бас нам ч дуугарч байна. Намын хурлууд дээр “нуугдагсадыг” хайн илрүүлж, коммунистууд хэнхдэг цээжээ балбан, ажсангүй, анзаарсангүй хэмээн алдаа дутагдлаа хүлээж гэмшицгээж байна. Гэтэл ингэлээ гээд нэмэргүй. Ингэж гэмшихийг хангалтгүй, чин санааных бус гэж үзнэ.

Гэрийн эзэгтэй пийшингээс ширмэн тогоотой төмсөө гаргалаа.

Саша Савва Лукичийг ширээ рүү урьж хоюулаа сууцгаалаа. Эхний жүнзтэйгээ татаж идэх юмаар даруулснаа хоёрдахиа хундагалацгаав.

-Ингэхэд би яагаад азтай хүн болж байна? гэж Саша асуув.

Всеволод Сергеевич загасны хөрсийг хуулах зуур,

-Яагаад гэвэл та Мозговод ямар ч хор холбогдолгүй байдалд аж төрж байна. Хэрвээ та эрх чөлөөтэй байсан бол тэр хурал цуглаанд заавал оролцож илчлэх, буудан алах, устгахыг шаардаж байх байсан шүү дээ гэв.

-Оролцохгүй байсан ч чадах л даа.

-Тэгж чадахгүй ээ. Үйлдвэрт ажиллаж байлаа гэхэд та цуглаанаас хаашаа ч зайлж чадахгүй, тийм эчнээ шүүлтээс мултрахгүй л байсан. Та заавал үг хэлж, хэн нэгнийг ардын дайсан, дайсны гар хөл буюу гэмшээгүй этгээд, нуугдмал этгээд гэхчилэн хуруугаар чичлэх байсан гэж би яриагүй байна. Үгүй! Гэхдээ та бусдын хамт буудан алахын төлөө саналаа өгч гар өргөх байсан, яагаад гэвэл та гараа өргөхгүй юм бол, бусдаас эсрэг санал өгөх юм бол та өөрөө дайсан болно гэсэн үг. Тэгвэл таныг тэр хурлаас л авах зүгт нь аваад явчихна шүү дээ.

-За тийм байж. Та бол яах байсан бол?

-Би юу? Надад тийм зовлон байхгүй. Зөвлөлт засаг байгаа цагт надад цөллөг-хорих-шорон-дахиад хорих-дахиад шорон гэдгээс өөр зам байхгүй. Хориход юм уу, шоронд тийм хурал цуглаан хийх санаа тэдний толгойд арай орж ирэхгүй болов уу гэж найдаж байна. Шоронд буюу хориход тийм юмны төлөө хэн ч гар өргөхгүй.

-За яахав, таны хугацаа дуусч суллагдлаа гэж онолын хувьд авч үзье. Та аль нэг хотод аж төрж ажил хийж байг, тэгээд танай ажил дээр цуглаан болж дайсныг илчлэн буруушааж, буудан алахыг шаардацгаан, бүх хүн нэгэн дуугаар санал өгцгөөж байна гэж саная, тэгвэл та саналаа өгөх үү?

Всеволод Сергеевич үг дуугүй хадрангийн хөрсийг зумлана.

-За, яах байсан бэ? Саша гэж асуув.

-Бүү мэд, Саша, үнэнээ хэлэхэд мэдэхгүй байна. Тэр хурал цуглаанд оролцож байгаа хүмүүсийн чинь дотор сонинд чин санаанаасаа итгэдэг, толгой руу нь чихээд байгаа юманд үнэмшдэг улс бий. Магадгүй итгэхгүй ч гэсэн бага балчир хүүхдүүдээ бодож байгаа ч хүн бий.

-Танд хүүхэд байхгүй шүү дээ.

-Байхгүй. Ер нь танд шулуухан хэлчихэд би ч гэсэн гараа өргөх л байсан байх л даа. Яагаад вэ гээч? Яагаад гэвэл ганц миний санал юуг ч өөрчлөхгүй. Яагаад гэвэл өндгөөр чулуу хагалж болохгүй. Эцэст нь бас хэлэхэд, би ганцаараа цаазын тавцан руу очлоо ч гэсэн юу ч өөрчлөгдөхгүй, нөгөөдүүлийг чинь буудан алдгаараа ална, харин намайг хоморгонд нь цуг

тонилгочихно. Гэтэл тэд чинь аль нэгэн бурууг худлаа хүлээж гэмшиж халаглах нь бий, тэгэхээр тийм хулчгар арчаагүй хүмүүсийн төлөөнөө би яахаараа амиа золионд өгч байх ёстой билээ? Тэд нар чинь коммунистууд, комсомолчид. Ийм явдлыг тухайн үедээ өөрсдөө зохион байгуулсан улс шүү дээ, тэд нар л хүмүүсийг үхлийн замаар тонилгож байсан, одоо өөрсдийг нь тэгж байна, тэгэхээр би юу боллоо гэж тэднийг хамгаалах ёстой билээ?

-Гэхдээ та чинь хуучны язгууртан, хөрөнгөтнүүдийг, бас тэдний үр хүүхдийг цөлж байгаа гэж ярьсан шүү дээ. Тэр үр хүүхдүүд бол хэнийг ч үхлийн замд оруулаагүй. Тэднийг чинь хамгаалах хэрэгтэй биз дээ.

Всеволод Сергеевич загасныхаа хальсыг сая нэг зумлаж дуусаад нэгэнтээ хазсанаа,

-Мөн ч сайхан загас, ёстой ванлий хэмээгээд, Саша, та их ноцтой асуудал гаргаж ирж байна. Маш ноцтой, нэн тулгамдсан асуудал. Гэхдээ миний хувьд биш, таны хувьд тулгамдсан асуудал, Саша. Миний хувьд энэ тухайд хэзээ ч сэтгэл хоёрдох явдал гарахгүй, би бол өөр тэнхлэгт байгаа хүн. Харин та бол, Саша, энэ гүрний эргэж байгаа чухамхүү тэр тэнхлэг дээр тэдэнтэй цуг байгаа хүн, та тэр тэнхлэгээс мултрана гэж байхгүй, нөгөө асуудал таны өмнө заавал гарч ирнэ гэв.

-За яахав, тэр асуудлыг гарч ирсэн цагт нь би шийдэх аргаа бодно. Харин таны шийд бол миний сэтгэлд нийцэхгүй байна гэж Саша өчив.

-Би дутуу бодсон учраас тэр шийднээсээ ухарлаа. Би зүгээр л миний оронд хэн ч бай аливаа хэрсүү хүн яах байсан тухай л ярьсан юм. Тийм хүн бол гараа өргөж л орхино, бусад нь бүгдээрээ тэгж байгаа учраас дагаад л өргөнө. Оросын эмгэнэлт явдал энэ, оросын ард түмний эмгэнэлт явдал ч энэ. Тийм учраас би хэнийг ч буруушаахгүй байна. Хүмүүс бол хүмүүс, хүн бол хүн.

-Тэгвэл нөгөө “ард түмний онцгой зориулга”, түүний “онцгой үүрэг” энэ тэр маань юу болох билээ? Ард түмний нөгөө “үнэн алдарт загалмайт сүсэгтний ёс” маань яах вэ?

-Саша, та ийм хээгүй асуултаар манай... манай ч юу байх вэ дээ, миний гүн ухааны сургаалийг няцаах гээ юү?

-Би гүн ухаантан биш, гэхдээ аль ч ард түмэнд арван хорын үндсийг таслах үүрэг, зорилго заяагдсан бус гэж үнэн голоосоо итгэх болж байна. Дээд үндэстэн, дээд ард түмэн гэж байхгүй, хүмүүс л байна. Сайн хүмүүс, муу хүмүүс. Тэгэхээр хүнийг ямар ч хүчээр албадаж муу болгодоггүй тийм л нийгэм байгуулах хэрэгтэй.

-Саша, төгс төгөлдөр нийгмийн тухай аливаа санаа бол хоосон мөрөөдөл.

-Тийм л дээ, төгс төгөлдөр нийгэм байхгүй, байх ч боломжгүй биз. Гэхдээ төгс төгөлдөр болохыг э р м э л з э ж байгаа нийгэм бол сайхан нийгэм даруй мөн.

-Манай нийгэм тийм болох гэж тэмүүлж байгаа нь нэг их харагдахгүй юм. Нийгэм гэдэг бол хүмүүс, гэтэл бид тэднийг хүн биш болгож байна гээд Всеволод Сергеевич босч,

-Явна аа, би бол маргааш өдөржингөө унтсан ч хамаагүй, та бол ажилтай хүн. Танд мужааны ажлыг итгэж өгснийг харж байгаа биз дээ, надад бол тэр чинь болохгүй гэлээ.

Саша инээд алдаж гэрийн эзэн рүү дохиод,

-Надад ивээгч бий. Савва Лукич тус болсон юм гэв.

-Туслахгүй гээд яахав? Тэр ажлыг дуусгах ёстой шүү дээ. Дарга нар тушаал буулгасан юм чинь гэж Савва Лукич ярианд оролцов. Всеволод Сергеевич,

-Тэгвэл намайг бас авчихмаар даа гэсэнд,

-Чи бол номын хүн, эрдэмтэн, маний ажил чамд муухай санагдана гэж Савва Лукич өчив.

Всеволод Сергеевич яваад өгөв.

Саша ээжийнхээ хэдэн захидлыг дахин уншиж, Варягийн зурвасыг бас гүйлгэж харав. Товч даруухан ч гэсэн эдгээр цөөхөн үгнээс далд утга санаа олж үздэг билээ. “Аж төрж байна, ажлаа хийж байна... санаж байна. Бид чамайг хүлээсээр сууна”.

Саша хариуд нь хэллэг болгоноо нягтлан бодож байгаад бас товчхон хэдэн үг бичнэ. “Хонгорхон Варя минь, би захиа ирэх тоолонд эхлээд чамаас ямар мэдээ сэлт байна гэдгийг л бушуухан хардаг юм”. Варя энэ хэдэн үгний цаанаас ямар нэг санаа олж үзэж магад.

Үүнээс илүү юм бичиж эс зүрхлэнэ. Москвад байхдаа Варяг гойд-лон сонирхдоггүй байсан юм чинь одоо сээтгэнэх аваас эрх чөлөө мөрөөдсөн, танил нөхдөө үгүйлсэн буюу зүгээр л эм хүний хүслэн болсондоо тэгж буй мэт ойлгогдож мэднэ. Саша буруу ойлгогдох хүсэлгүй байгаа билээ.

Варя “Чиний одоо юу хийж байгааг мэдэхсэн гэхээс би ёстой байж ядаж байна” гэж бичсэнээрээ илүү зориг гаргаж, илүү шийдтэй харьцах гэж оролдсон байж ч магадгүй, эсвэл өр нимгэн цайлган бүсгүй өөрийг нь зүгээр л сэтгэл санаагаар дэмжих гэснийг манай хүн хэт сайхнаар ургуулж бодсон ч байж магад.

“Аж төрж байна, ажлаа хийж байна... санаж байна. Бид чамайг хүлээсээр сууна”. Энэ үгсийн цаана ч ямар нэг санаа байгаа л даа, мэдээж... Ямар ч атугай Саша бүсгүйн энэ хэдхэн харам үгийг сэтгэл догдлон хүлээдэг билээ. Варягийн ирээдүйдээ итгэх бат итгэл түүнд ч горьдлого төрүүлнэ.

Ээжийнх нь захидлуудын хөг аяс сэтгэл зовоох юмгүй мэт хэрнээ ямар нэгэн түгшүүрийн амьсгаа мэдэгдээд байх шиг. Ээж нь нэг захидалдаа Вера эгчийнх нь тухай “Верагийн зуслангийн байранд өвөлжихөд ер дажгүй ч гэсэн тэднийх нүүгээд ирсэн. Түлээ мод, гал хөстэй ноцолдох дургүй гэнэ” гэж бичжээ. Энэ мэдээнд гойд юм ер алга. Гэтэл дараачийнх нь захианд бас л “Вера зуслангаа өвөл хаачихсан” гэжээ. Энэ юу гэсэн үг вэ? Яагаад хоёр удаа дараалан дурсаж байна? Мартаж санасандаа тэр үү? Эсвэл Вера эгч, түүний нөхөр энэ тэрд ямар нэг юм тохиолдоо юм болов уу. Эсвэл хүү охин хоёрт нь элдэв юм учраа юу. Тэрээр

ээждээ “Вера эгч, Володя ах (эгчийнх нь нөхөр), Светлана, Валера (хоёр хүүхэд нь) энэ тэрийн биесүүд сайн уу? Хаана, яаж шуухан байцгаагаа вэ?” гэж бичив.

Ээжийгээ тайтгаруулж байх хэрэгтэй. Тэгээд энэ захидалдаа бич-гийн шургуулган дотор дээд сургуулийн дүнгийн дэвтэр, жолоочийн үнэмлэх (энэ хоёрыг нэгжлэгийн үед хурааж аваагүй юм) хоёрыг үзээрэй, олдвол өөрийг нь очтол сайн хадгалж байгаарай, сүүлд хэрэг болно гэж бичив. Гагцхүү ээжийгээ тайвшруулах гэж, мөд буцаж харина хэмээн итгүүлэхийн тулд, хүү нь суллагдана гэсэн горьдлогыг нь бататгахын тулд л ингэж бичсэн хэрэг. Суллагдана гэдэгтээ өөрөө бол огт итгэхгүй байгаа билээ. Бас Францын их хувьсгалын тухай зарим нэг номоо явуулаарай гэж бичив. Тэрээр дунд сургуульд байхдаа энэ хувьсгалын түүхийг нэлээд үзсэн, хожим ч тэр тухай сонирхож олон ном цуглуулсан, одоо түүнээ санагалзаж, эргэж уншмаар санагджээ. Үүнээс гадна саалийн ферм барих ажил хийж байна, хөлс сайтай аятайхан ажил юм, хоол хүнс, орон байрны зардалд хүрэлцэж байна, тийм учраас мөнгө гуйвуулах хэрэггүй гэж бичив.

Саша захиа бичиж зөндөөн удав. Пийшин дээр унтаж буй гэрийн авгай хүртэл тээршээж,

-Ингэж нүдээ зовоогоод яана? Ороо засаад хэвтэж үз гэж бувгнав.

-Буцах шуудан маргааш явна, захиагаа гүйцээлгүй болохгүй гэж Саша хариулав.

Тэрээр орой хэвтсэн болохоор Савва Лукичийг өглөөнийхөө ундыг ууж байхад сэрэв.

-Өө, Лукич гуай, би гялалзчихъя!

Саша түргэн хувцаслаж гар нүүрээ угаагаад, ширээн дээрх шарсан өндгийг идэхээр суулаа.

Өвгөн гадагшаа гарав. Саша араас нь,

-Явж бай, би гүйцээд очно гэв.

Савва Лукич тэр дорхноо буцаад ороод ирэв.

-Цагдаатай чарга айсуй...

-Манай руу юу?

-хэн мэдэхэв.

Бэлдсэн, эмхэлсэн юм гэж юу ч байдаггүй. Саша захидлууд руугаа нэг ухасхийж үзэв. Хөндлөнгийн хүний гар хүргэхгүй гэсэндээ тэр. Гэвч мань хүн юу ч эмхэлж амжсангүй. За яахав, хүрч ирээд хүлээзнэж байна биз, юу л болов гэж.

За ингээд гүйцдэг байж. Ангарт аж төрөх хугацаа дууслаа. Хаана, ямар гэгч хориход аж төрөл маань үргэлжлэх бол? Ээжтэйгээ дахиад хэзээ ч уулзахгүй байх, эцэгтэйгээ ч уулзахгүй, Варятай ч уулзахгүй байх.

Тэрээр хайрцагтай тамхинаасаа нэгийг авч асаалаа. Цонхоор харах гэтэл нэл цантсан учраас юу ч харагдсангүй. Чимээ чагналаа. Гэтэл чарганы хяхрах дуу ч бас сонсогдсонгүй.

Хашааны бага хаалга дуугарч, төдөлгүй үүд нээгдэн Савва Лукич орж ирээд,

-Саня, өнгөрөөд явчихлаа, ээ бурхан минь хэмээн загалмайлан залбирав.

-Хаашаа явчихав?

-Тэр булангийн цаагуур эргэлээ.

“Тэр” гэдэг нь хоёрдахь буланг хэлж буй хэрэг, нэгдэхийг “энэ” гэдэг юм.

хэнийг авах нь юм болоо? Масловыг байхаа даа.

-Лукич, би түүгээр шүргээд гаръя, тэгээд ажил руугаа очно.

-Тэг, тэг, яарах юу байхав, бид амжихаа нэг амжина гэж өвгөн өгүүлэв.

Чарга Масловын суудаг байшингийн гадаа хүлээж харагдана.

Всеволод Сергеевич, Петр Кузьмич хоёр бас тэрүүхэнд нь зогсож байна.

Сашаг яг дөхөж очтол Михаил Михайлович Маслов үүргэвчээ үүрчихсэн, хайрцгаа барьсаар гарч ирэв. Энэ чинь хэдийдээ амжуулаад юм хумаа эмхэлчихээ вэ? Яг зэхчихсэн хайрцагтай байсан болж таарлаа гэж үү?

Масловын урд нь нэг буутай цагдаа, ард нь бас нэг буутай цагдаа дагажээ. Арынх нь занасан янзтай хөмхийгөө зуусан өндөр залуу.

Маслов хайрцгаа чарган дээр тавив. Үүргэвчээ мөрнөөсөө мулталж бас тийш нь тавилаа.

Тэгснээ Всеволод Сергеевич рүү эргэж очив. Тэр хоёр тэврэлдэн үнсэлдэв. Петр Лукичтэй бас тэврэлдэн үнсэлдэцгээв. Сашад гараа өглөө. Саша гар барих зуур Михаил Михайловичийн нүд рүү эгцлэн харлаа. Дараа нь,

-Михаил Михайлович, та Ольга Степановнад уламжлах зүйл байхгүй юм уу? гэж асуув.

- Всеволод Сергеевичид хаяг нь байгаа, тэр захиа биччихнэ.

Хэсэг зуур бодолхийлснээ,

-Тэр тухай санасан чинь сайн байна, баярлалаа... гэв.

Саша барилга руугаа очлоо. Харчуул доод яс модон дээрээ нэг үнээний байрны хэмжээгээр хоёр хоёр метрийн зайтай шон босгож байна. Шонгоо хөдөлгөөнгүй байлгах үүднээс углуургадан зооно. Шон нь уртынхаа энгээр ховилтой, түүнд нь дүнзнүүдээ хэвтээгээр нь суулгаад хана болно.

Нарийн сайхан ажил. Ийм ажлыг сүх, түлээний хөрөө, гар хөрөө, том бага цүүц, урт богино харуул, хусуур мэтийн хээгүй багажаар яаж болгож байгаа, утсан дүүжингээр тэгшлүүрийн нарийн хэмжүүрийг яаж орлуулж чадаж байгааг Саша гайхан бишрэх бүлгээ.

Уул нь мань хүн ч ийм ажлыг дөнгөх учиртай, гэвч өнөөдөр хожимдож ирсэн учир дээд талын яс модны дүнз цавчих ажилд дахиад тавьчихжээ.

-Нөхрөө үдээд явуулчихав уу? гэж Савва Лукич асуув.

-Үдээд явуулчихлаа.

-Хааш нь туугаад явчихаж байгаа юм бол? гэж Степан Тимофеевич гэдэг бөгтөр хамартай, хатингар хар эр сониучирхахад, Саша,

-хэн мэдэхэв гэв.

-Хугацаа нь дууссан ч байж мэднэ гэж Савва Лукич өгүүлэхэд, Степан Тимофеевич,

-Тэгвэл суллагдах хэрэг үү? Цагдаагаар туулгаж сулладаг ёс байхгүй гэж тамшаалав.

-Кежмийн харчуул ярих нь нэг даргыг алчихсан юм байх. Бас сонинд бичиж байгаа гэнэ. Тэгсэн чинь тэрнийг нэг троцкист алчихсан юмсанж. Троцкист гэдэг нь хамтралыг эсэргүүцдэг, энэ муусайн хамтралыг тараана барина гэдэг юм байна гэж бас Степан нэртэй гэхдээ Тимофеевич биш Лукьянович хэмээгдэх нэг эр ярив.

-Одоо эднийг чинь хааш нь буулгаж, юугий нь тарааж өгөх юм бэ? Юугаар гийгүүлэх болж байна? Хамаг юмаа эвдэж бусниулчихаад... гэж Степан Тимофеевич үглэв.

-За, яахав, чи ингэхэд нэг их яах хэрэггүй шүү гэж Савва Лукич ийш тийш хулмаганаан өгүүлэв.

-Юуг яаж хэрэггүй гэж?

-Юусах юу байхав, бүх юм бурханы тааллаар шүү дээ, бурхан тэнгэрээс яаж заяасан байна, тэр ёсоор л явна гэж Савва Лукич хариулав.

-Бурхан гэнэ шүү, хамаг юмыг бурханд нялзаах нь гэж Степан Тимофеевич шартай өчөөд, -Та нарын нөгөө сүм хийд чинь хаана байна? Бурхан чиний өмнөөс юу ч хийхгүй, энэ үнээний байрыг бурхан бариад өгөх үү? Үнээгээ хөнөөгөөд байгаа хэрнээ үхрийн байр бариад л гэв.

-Чи тэгвэл битгий барь л даа гэж Евсей гэдэг өөр нэг өвгөн хэлэв. Саша давхар нэрийг нь мэдэхгүй, хэн хүнгүй л Евсей гэх, заримдаа толгой холбосон эвгүй үгээр хослуулан нэрлэх нь бий.

-Барихгүй гээд хаачих вэ дээ? хэмээн Степан Тимофеевич зэвүүрхээд Саша руу зааж, -Эднүүс бол хугацаа дууслаа л бол дуртай зүгтээ арилад өгнө. Гэтэл хөдөөний бидэнд хаашаа ч явах зам алга. Бид бол паспортгүй амьтад. Ганцхан газар хадуулчихсан улс. Нөгөө эрх чөлөө гэдэг чинь энэ! гэв.

-Ямар тахилыг чинь буруу өргөчихөө вэ? хэн нэг нь сонсоод алтан хошуу өргөчихвөл юу болдгийг мэднэ биз дээ? гэж Савва Лукич өгүүлэв.

-Мэдэлгүй яахав. Амаа үдүүлчихсэн юм шиг дуугүй байгаагаасаа болоод л амиа алдацгааж байгаа юм чинь гэж Степан Тимофеевич бухимдав.

-мань мэт нь ажлаа хийж байвал барав биш үү, бурсаар байгаад өдрийн хагасыг барчихлаа.

Үнэхээр ч юу юугүй үд болох гэж байв. Нөгөө хэд дахиад ажилдаа шамдацгаалаа.

Харчууд яриад баймаар бололтой, ер нь ч ярихгүй байхдаа ч яахав дээ, гэвч Саша хөндлөнгийн хүн болохоор тэдний ярианд саад болоод байгаа нь илт. Хөндлөнгийн хүний дэргэд амаа хамхиж байсан нь дээр гэдгийг тэд нар мэдэх л дээ... хөөрхийлөлтэй хэрэг шүү.

Нэг хоёр долоо хоногийн дараа Петр Кузьмичийг Кежма руу дуудлаа... Цагдаа энэ тэр ирсэнгүй, зүгээр л тосгоны зөвлөлөөр дамжуулан, тэдний өдөр бэлэн бай гэсэн мэдээ иржээ.

Тэрээр Саша, Всеволод Сергеевич хоёроос дэмжлэг горилон царайчлан харж,

-Хөөе, та хоёр минь ээ, намайг суллагчид юм биш биз? Миний хугацаа аль арван нэгэн сард дууссан шүү дээ гэлээ.

-Дууссан юм бол та юу гээд энд хоргодоод байсан юм бэ? Өөрөө сануулах байж л дээ гэж Саша өгүүлэв.

Петр Кузьмич толгой сэгсрэн,

-Сануулах чинь гэмтэй, Александр Павлович минь. Сануултал цаадуул чинь дахиад шинэ хугацаа нэмээд өгчихнө... гэснээ, -Уул нь миний зүйл анги улс төрийнх биш. Михаил Михайлович шиг тууж аваачихгүй байна шүү дээ хэмээхэд Всеволод Сергеевич,

-Улс төрийнх биш гэнэ! Хувьсгалын эсэргүү эдийн засгийн явуулга гэдэг чинь чамлах зүйл биш байх гэж тамшаалав.

-Ямар ч атугай улс төрийнх биш эдийн засгийн гэж Петр Кузьмич зөрөхөд Всеволод Сергеевич түүний үгийг тасдан,

-За яахав, Кежма руу очоод л мэд, тэгээд бидэнд ярьж өгөөрэй гэв.

Петр Кузьмичийг Кежма руу явсны дараа Всеволод Сергеевич Сашад,

-Нээрэн суллагчид мэдэх юм шүү, хүнд суртлын будлианыг алийг тэр гэх вэ... Бүртгэлийн хуудас байж байдаг, хугацаа дуусчихсан байдаг, гэтэл ямар ч шийдвэр чиглэл байдаггүй... Одоо, мэдээж, Кировын хэрэг явдлаас хойш... Гэвч юу эс болохов, харж л байя гэж хэлэв.

Петр Кузьмич оройхон бөөн баяр хөөр болсоор эргэж ирлээ. Суллагджээ! Бичгээ үзүүлж байна. “Хорих хугацаа дууссаны учир... Ардын Комиссаруудын Зөвлөлийн паспортын дэглэмийн тухай Тогтоолын II зүйлд хамаарна”. Тэгэхээр муу нь юу вэ гэвэл, том хотуудад аж төрж болохгүй.

-Би том хотоор яах вэ дээ, надад тэрүүн шиг хэрэггүй юм байхгүй. Би Старый Осколд л төрж өссөн хүн, авгай хүүхэд, хамаатан садан маань тэнд байгаа. Тэндээ л аж төрнө хэмээн Петр Кузьмич тун дэврүүн ярьж байв.

-Замын унааны өртөг бий юү? гэж Саша асуув.

-Харьчихна аа... Кежма хүрэх тухайд улаачтай тохирсон, пүүгээгээ арваар хүргүүлнэ. Старый Оскол хүртэл тасалбарын үнэ бодвол 25-30 байх. Нийтдээ тавьд багтана. Надад тэр хэрийн юм бий.

-Идэх уух юм яах...

Петр Кузьмич санаа зоволтгүй гэсэн шиг гараа сэгсэрч,

-Өлбөрч үхэхгүй ээ. Айлын эзэгтэй талхны боорцог хайрч, утсан загас, хэдэн өндөг өгнө, төмөр замын буудал болгон дээр буцалсан ус үнэгүй байх юм чинь... Та хоёр санаа зовохын хэрэггүй, дөнгөөд харьчихна гэв.

Петр Кузьмич маргааш нь зам таарсан хамтралын морин чаргаар Кежма руу яваад өгөв. Саша, Всеволод Сергеевич хоёртой салах ёс хийхдээ нулимс унагасан нь өөрт оногдсон азнаас ичсэнийх байж.

-Бурхны авралаар та хоёрын ч гэсэн учир олдоно доо.

-Бурхан аврана аа, аврана хэмээн Всеволод Сергеевич дооглонгуй өөриймсөг өгүүлснээ, -Та нутагтаа очоод амар жимэр аж төрөөрэй, мухлаг нээх энэ тэр гэсний хэрэггүй гэв.

Өвгөн хирдхийн цочиж,

-Хаанаас даа, Всеволод Сергеевич минь, одоо цагт юуны чинь мухлагтай манатай. Худалдагч болчихвол башийх нь тэр! гэв.

-Манаа хийсэн нь дээр гэж Всеволод Сергеевич хэлэв.

-Яагаад тэр билээ?

-Биенд амар. Дэлгүүр эдийн хариуцлагатай, элдэв юм болвол өөчлөөд салахгүй. Харин манаа бол дах нөмөрчихөөд л дулаахан сууж байна...

-Үгүй шүү, Всеволод Сергеевич минь, яаж тэгж болох вэ? Би хар багаасаа тэр ажлаа мэднэ, бас ч гэж ашиг тусаа өгч чадна гэж өвгөн чарган дээр гарах зуур хэлэв...

Улаач жолоогоо дугтарч морьд хөдөллөө.

-Үүрд баяртай, бурхан өршөөх болтугай гэж Петр Кузьмич хашгирахад Всеволод Сергеевич,

-Юу ч ухаарсангүй дээ, хөөрхий гэж урамгүй өгүүлжээ.

Петр Кузьмич суллагдсан нь сэтгэл жаахан сэргээв. Нэмэрт нь төдөлгүй бас нэг мэдээ иржээ. Заимка тосгонд байсан Василий хуврагтан хугацаа дууссаны учир суллагдсан гэнэ. Тэгэхээр бүх нийтийг хамарсан бус хэсэгчилсэн үйлдэл байх нь. Бүхнийг толгой дараалан хоморголоогүй наанатай цаанатай үзэж байх нь.

Гэтэл түүнээс долоо хоногийн хойно үнээний байр руу нэг охин гүйж ирж Сашагийн дэргэд зогтусаад,

-Севолод Сергеич чамайг дуудаж байна гэв.

Энэ охин Всеволод Сергеевичийн байдаг айлын хүүхэд. Всеволод Сергеевичийг явуулах гэж байгааг Саша тэр даруй ойлгов.

Сашаг очиход мань хүн бүр сэргэчихсэн, юм хумаа эмхлээд сүйд байв. Тэрээр урьд өмнө юу болох, юу хийхээ мэдэхгүй хоног тоолон зовдог байсан бол одоо дахиад замд гарах болж бүх юм шийдэгджээ. Одоо түүнийг чухам юу угтан золгохыг гарцаагүй мэдэж буй. Бас угтан буй замд хүч хэрэгтэй, юу ч тохиолдсон өөрөө бэлэн байх ёстойг мэдэж буй.

-Таныг ир гэж тушааж уу? гэж Саша асуув.

-Ялгаа юу байх вэ дээ?! Намайг авах хүмүүс Кежмаас ирцгээнэ. Тэнд Красноярск руу өртөөлөн туух сүүлчийн жижигхэн бүлэг байгаа бололтой. Та тэр бүлэгт орсонгүй, тэгэхээр горьдлоготой гэсэн үг. Гэхдээ дахиад олон бүлэг гарна даа, тийм учраас, Саша, чи юу ч болсон бэлэн байгаарай... Лидия Григорьевна Звягурог энэ бүлэгт оруулсангүй, уул нь өнөөгийн хэрэг явдлуудын байдлаар бол түүнийг заавал авах ёстой юм, гэтэл түүнд гар хүрэхгүй байна. Тэгэхээр юм барагдах яагаа ч үгүй гэсэн үг гээд Всеволод Сергеевич хэсэг ном руу зааж, -Энэнийг танд өгч байгаа юм. Та гүн ухаан жаахан сонирхдогийг би мэднэ, гэхдээ энэ дотор сонин номнууд бий, би ямар өөрөө чирч явалтай нь биш... Ер нь ч тэртэй тэргүй хураагаад авчихна... Таныг явуулах цаг ирвэл хэн нэгэн хүнд үлдээчихнэ биз, аргаа барвал хаячихгүй юу гэв.

-Баярлалаа, танд дутуу гуцуу юм байна уу? гэж Саша асуув.

-Бүх юм л байх шиг байна.

-Танд, дотуур дулаан хувцас байхгүй биз дээ?

-Би дулаанд дасаагүй, ердийнхийг өмсдөг хүн. Тэгээд ч өвлийн хоногийн тоо гүйцэж байна.

-Надад анчных байхгүй, харин тэрмэн хувцас хоёр хос бий. Ноосон оймс бас.

-Тийм юм хэрэггүй.

-Надад нэг илүү ноосон цамц бий, та ав.

-Саша аа, элдэв юм хэрэггүй... Эрүүгийн ялтангууд булаагаад авчихна.

-Красноярск хүртэл булаахгүй... Би таны бээлийг харсан, өрөвдмөөр юм байна лээ.

-Үгүй ээ, миний бээлий сайнаараа байгаа.

-Би танд хандгайн арьсаар хийсэн сайхан гадуур бээлий өгье, давхар өмсчихгүй юу, юу шиг дулаахан байхав. Гутал юу билээ?

-Би сайхан гуталтай, харахгүй юу, тоногтой эсгий гутал. Саша, одоо болно... Бусад бүх юм байна. Мөнгө л байхгүй. Гэхдээ одоо улс намайг асрамжиндаа авч байна.

-Ингэхэд таныг авахаар ирнэ гэж та яаж мэдэж байгаа юм бэ?

-Мэдэж л байгаа юм даа гэж Всеволод Сергеевич товчхон хариулав. Тэрээр Сашагаас айдаггүй, түүнд итгэдэг боловч хүний нэр хэлсэнгүй. Эндэхийн амьдралын дэгээр хэний ч нэрийг илчлэх ёсгүй билээ.

Всеволод Сергеевичид хогшилсох юм юу байх вэ, ердөө л ганц үүргэвчинд чихэж хийгээд таарав.

-За ингээд юмаа эмхэлчихлээ.

Всеволод Сергеевич сандайлган дээр суузнав.

-За, Саша, салахын цагт би чамд юу хэлэхсэн билээ. Үнэнийг хэлэхэд танаас салж одоход гунигтай л байна, би таныг хайрладаг болчихсон шүү. Та бид хоёр одоо цагт ярьдагчилан хамгаалалтын хэрэмний хоёр талд байгаа ч гэсэн би таныг хайрлаж хүндэлдэг юм. Таныг итгэл үнэмшлээсээ няцаагүй гэж хүндэлж байгаа юм биш, тань шиг хүн зөндөөн олон. Гэхдээ таны итгэл бол бусдынхтай адилгүй, анги, намын явцуурал байхгүй, харин ч хүнлэг ёсны үнэртэй. Магадгүй, та өөрөө мэддэггүй ч байж болно, таны итгэл бол хүний жинхэнэ эрхэм нандин тэмүүлэлтэй хүйн холбоотой байдаг юм. Энэ бол таны тухайд миний гойд үнэлдэг зүйл. Гэхдээ би бол танаас хэдэн оймс илүү элээсэн илүү хашир хүн. Та битгий л чин хүслэнтэн болчихоорой. Амьдралд аль болохоор ойр байгаарай. Эс тэгвэл амьдрал таныг үгүй хийнэ, эсвэл дарж авна, тэр бүр ч аймшигтай, нэг тэгсэн цагт... Би шулуухан ярьж байна шүү, уучлаарай. Чин хүсэлтэнгүүд заримдаа хувилгаан болчихдог юм. Гэхдээ ихэнхдээ харгислагч буюу харгис ёсыг хамгаалагч болж хувирдаг... Энэ хорвоо дээр хичнээн олон

увайгүй явдлыг эрхэм хүслийн нэрээр зөвтгөж, хичнээн олон муу хорыг эрхэм хүслээр хаацалж байгаа билээ. Та надад муу юм санаагүй биз?

Саша мушилзан,

-Хаанаас даа, Всеволод Сергеевич минь! хүний бодол эрэгцүүл-лийн төлөө муу санаж болно гэж үү? Ер нь ч би таны онолтой маргах бодолгүй байна. Би өөрийнхөө ирээдүйн тухайд ч барин тавин хэлэх юм алга. Ганцхан юм хэлж болох байна. Би бол газар дээр аж төрж байгаа газрын хүн. Чухамхүү энэ учраас таны яриад байгаа тэр чин хүсэлтэн чинь биш. Би бол чин хүсэлтний тухай өөрийн ойлголттой, өөрөө ч тийм хүн. Юу гэвэл, би аливаа нэг үзэл бодол баримтлах ёстой гэж үздэг, харин тэр нь хүний ёсны, хүнлэг, шударга үзэл бодол байх ёстой. түүнээс гадна шоронд хоригдож, цөлөгдөж, туугдаж яваа энэ нэг жилд ямар дүгнэлтэд хүрэх гэхээр, нарт орчлонд хүний амь нас, хүний нэр төрөөс өөр үнэтэй цэнэтэй, ариун нандин зүйл гэж үгүй юм байна. Тэгэхээр хүний амь насанд халдагч ч гэмт хэрэгтэн, хүнийг хүн гэхгүй доромжлон муулагч ч гэмт хэрэгтэн гэв.

-Гэтэл гэмт хэрэгтэнг чинь шүүх хэрэгтэй шүү дээ.

-Тийм, шүүх хэрэгтэй.

-За тэр, таны энэ эрэгцүүлэлд хий гараад ирлээ. Шүүгч нь хэн байх вэ?

-Хоюулаа уг асуудлын харанхуй шугуй руу орохоо больё. Нартад хамгийн үнэтэй цэнэтэй юм бол хүний амь нас, хүний нэр төр гэдгийг дахин хэлье. Хэрэв заяа энэ зарчмыг гол тулгуур болох чин хүслэн гэдгийг хүлээн зөвшөөрсөн байхул хүмүүс цаг нь болоход салбар асуултуудын хариуг боловсруулаад гаргаад ирнэ.

Всеволод Сергеевич чимээ чагнав. Гадаа чарганы мөөр хяхтнах сонсоглоо.

-За, намайг авахаар ирцгээлээ.

-Жаахан хүлээлгэж байгаарай, би одоохон эргээд ирнэ гэж Саша хэлэв.

Тэгээд байшингаас ухасхийн гарвал үүдэн тус зогсож буй нэгэн чарган дээр улаач цагдаа хоёр байх аж.

Саша гүйн хариад хоёр ширхэг тэрмэн дотуур хувцас, ноосон цамц, гадуур бээлий энэ тэрийг шүүрэн авч бас хоёр цамц нэмээд Всеволод Сергеевич дээр буцаж ирэв.

-Үгүй ер, та энэ их юм юунд авчрав? хэмээн Всеволод Сергеевич царайгаа үрчийлгэж, - Миний муу үүргэвч “тийрчихсэн” байгааг харж байгаа биз дээ гэв.

-Дажгүй ээ, чихээд хийчихнэ, онгойлго!

Тэр хоёр сайхь юмсыг үүргэвчинд хийцгээлээ.

-Өө тийм, Ольга Степановнагийн хаяг энэ байна, Калинин хот. Би нэг захиа биччихээд

байгаа, Красноярскаас явуулна гэж найдаж байна. Гэтэл тийшээ очтол шууд шоронд аваачиж мэднэ. Тийм учраас та бас нэгийг биччихээрэй, хоёрын хоёр захианы нэг нь эрхбиш заавал хүрнэ.

Саша хаяг бичсэн цаасыг халаасандаа хийв.

Цагдаа, улаач хоёр цай ууж дуусаад гарцгаалаа.

Всеволод Сергеевич гадуур хувцсаа өмсөөд, үүргэвчээ авч шалан дээр тавив.

-За, Саша, ингээд салцгаая даа.

Тэр хоёр тэврэлдэн бие биенээ үнсэцгээлээ.

-Та бид хоёр мэтгэлцээнээ дуусгаж чадсангүй шив хэмээн Всеволод Сергеевич инээмсэглэхэд Саша,

-Хэзээ нэгэн цагт гүйцээгээд маргачих ч юм бил үү гэв.

Всеволод Сергеевич гал тогооны өрөөнд орж гэрийн эзэдтэй салах ёс ёслоод, гадагшаа гарч үүргэвчээ чарган дээр тавив.

Үүдэнд оготор дээлээ мөрөндөө угласан айлын нөгөө охин зогсож харагдана.

-За, дахиад нэг!

Всеволод Сергеевич, Саша хоёр бие биенээ үнсэцгээв.

Всеволод Сергеевич чарганд сууж хөлөө хучаад,

-За, хөдөлцгөөх үү? гэж хөгжүүн дуугаар өгүүлэв.

Саша чарганы араас өнцөг тойртол харж зогсов.

Нөгөө охин бас үүдэндээ хараад зогсож байна.

Мозговод цөллөгийн хоёрхон хүн үлдлээ. Саша, Лидия Григорьевна Звягуро хоёр.

Арбатын аж төрөл энэ зуур бүгд хуучнаараа мэт. Цөллөг, шорон, хорих энэ тэрийн аль нь ч байхгүй мэт, хоригдол гэгч хүмүүс байдаггүй мэт аж амьдрал үргэлжлэн хөвөрсөөр.

Хоригдлуудын танил талынхан, бас тэдний танил талынхан бахь байдаг хуучин аясаараа амь зууцгаана. Эдний тухай, энэ жирийн хөдөлмөрчдийн тухай, яруу алдарт ажил үйлсийнх нь тухай сонин хэвлэлд нийтэлж, радиогоор мэдээлж, хурал цуглаан дээр ярьцгаана.

Саша Панкратов шиг хүмүүсийн тухай бас сонин хэвлэлд бичиж, радиогоор мэдээлж, хурал цуглаан дээр ярина. Гэхдээ устгавал зохих ардын дайсан гэж ярьж, бичнэ. Бас тэднийг дэмждэг, өрөвддөг хэнийг ч болов устгах хэрэгтэй гэнэ.

Өөрийгөө устгуулахыг хэн ч хүсдэггүй болохоор шүүхээр ял заагдаагүй, гэм буруугийнх нь тухай сонинд товчхон мэдээлдэг тэдгээр хөөрхий хүмүүсийг устгаж байх хэрэгтэй гэдэгт хэн ч эргэлзэж тээнэгэлзэж эс зүрхлэнэ.

Ерөөсөө тэдний тухай ор тас ярихгүй байсан нь л хал балгүй. Өөр юмны тухай ярьсан нь дээр. Жишээлбэл, ноднин осолд өртсөн “Челюскин” хэмээх усан онгоцны багийнхныг Мөсөн далайн мөсөн дээрээс зөөж аварсан эрэлхэг зоригт нисэгч нарын тухай. Хэрэв хэн нэгний толгойд гэм зэмгүй хүмүүсийг шоронгоос аврах нь “челюс-кинийхнийг” аврахаас дутуугүй чухал гэсэн санаа орж ирлээ гэхэд энэ тухай хүнд сонсогдохоор огтхон ч үл ярих бүлгээ.

Юрий Денисович Шарок эдүгээ гүйцэтгэх албаны ахлах төлөөлөгчөөр дэвшсэн учир нэг хөндөлтэй мөрдэс зүүж нэгдүгээр тасгийн дарга Александр Федорович Вутковский, түүний орлогч Штейн хоёрт шууд захирагдах болжээ. Дьяковт бас захирагдана, гэхдээ зөвхөн тасгийн даргын туслахынх нь хувьд л захирагдана.

Вутковский, Штейн хоёр Шарокийг шальдар бальдар зангүй, ажилд өөриймсөг, гүйцэтгэл сайтай ажилтан хэмээн үнэлнэ. Бас ирээдүйтэй гэгцгээнэ. Эндэхийн ирээдүйтэй хүн гэдэг нь мөрдөгдөж байгаа хүнийг “улайлгаж” өөрийнх нь бурууг хүлээлгэж чаддаг төдийгүй, хамгийн гол нь түүнийг холбоотнуудтай болгож, ганцаарчилсан биш бүлэглэсэн хэрэг бүрдүүлж чаддаг ажээ. Мөрдлөгийнхөн бүлэг хэргийн хамсаатнуудад бас дор бүрд нь шинэ холбоотон олно. Залхаан цээрлүүлэх байгууллагын тасралтгүй ажиллагааг хангах ажлын н ө ө ц иймэрхүү байдлаар бүрдэнэ.

Шарок үүнийг сайн эзэмшжээ. Түргэн ч эзэмшиж. Үүнээс өөр бас олон үнэнийг ухаарч эзэмшиж авсан байна. Тухайлбал, хэний ч хор-мойноос чаргуулдах хэрэггүй гэдгийг ойлгосон. Березин түүнд талтай байдаг боловч мань хүн хөндийрч цэрвэнэ. Тэр нь ч зөв

болж. Березин Алс Дорнод руу манаргаж арилсан. Уул нь ч том албан тушаалд шилжсэн л дээ. Цол хэргэм нь ч хэвээрээ үлдсэн. Гэхдээ л Москвагаас зайлуулсан хэрэг. Бас түүний харъяаны ажилтан нарыг хааш нь хамаагүй тараачихсан.

Шарок энд бас өөр нэг үнэнийг ухаарч хутганы ирэн дээр байгаагаа мартаж болохгүй, даварч болохгүй гэдгийг ой тойндоо ортол шингээжээ. Маш хянуур хашир байж гэмээж л тэснэ. Муу

тэнэг толгойт Дьяков өнөөгийн эрх мэдэлдээ эрдэж, ямар ч гэм зэмгүй, дур зоргоороо авирлаж байгаагаараа бардамнаж л байг. Хамгийн тулгамдсан алба хашиж байгаа гээд онгирууд л байж байг. Цаг цагаараа байх биш.

Тэдний тасаг хамгийн тулгамдсан албатай нь ч үнэн л дээ. Хоёрдугаар тасагт-меньшевикүүд, бундчүүд, анархистуудын хэрэг, гуравдугаарт-мусаватчууд, дашнакууд мэтийн элдэв үндсэрхэх хөдөлгөөнүүд, дөрөвдүгээрт-эсерүүд, тавдугаарт-сүм хийдэнхэн. Ёстой тайван тасгууд. Одоо ямар юмных нь меньшевик, эсерүүд байх вэ дээ...

Шарок тийшээ дуртайяа шилжвэл шилжихсэн. Сүм хийдийнхний хэргийг хариуцахаар тавдугаар хэлтэст шилжих боломж гарч байсан удаатай. Тэгэхэд мань хүн жаахан тээнэгэлзэж байгаад татгалзсан юм. Бурхан тэнгэртэй орооцолдохыг хүсээгүй хэрэг.

Шарок бурханд эс сүсэглэнэ. Гэхдээ ээжийнхээ сүсэг бишрэлийг хувийн хэрэг хэмээн тэвчин хүлцэнэ. Бас ч гэж хэн мэдэх вэ дээ! Эрдэм боловсролтой хүмүүс бурханд сүсэглээд л байх юм. Жишээ нь, академич Павлов. Үйлийн үргүй материалист үзэлтэн, дэлхийд нэртэй эрдэмтэн атлаа Колтушд сүм нээчихээд хөл малгай болж байгаа. Гэтэл Засгийн газар түүнийг эрхлүүлж, нөхөр Сталин хүртэл түүнийг хүндлэн үзэж байх юм.

Бурхан биш юмаа гэхэд учир нь үл олдох нэг юм ч байна шүү. Хувь тавилан юм уу... мань хүн 1934 оны есөн сард нэг муу мухар олгойноос болоод Ленинград руу Запорожец дээр очиж чадаагүйдээ хичнээн харамсаж гутарсан билээ. Гэтэл тийшээ явсансан бол өдийд шоронгийн тав болсон байх байлгүй.

Юра тэгэхэд заншсан ёсоор өглөөгүүр, бодвол долоон цагийн алдад болов уу, ажлаасаа бууж иртэл гэнэтхэн базлаад явчихжээ. Хамаг бие нь задчих мэт, өвдөж байгаа гэдэг нүгэлтэй, амьсгаа ч авч болдоггүй, зөв талаараа ч хэвтэж үзэж, буруу талаараа ч үзэж, атирч ч үзэж, эвхэрч ч үзэж, ерөөсөө нэмэр байдаггүй, ёйлон орь дуу тавьж.

Ээж нь арга барагдан “Халуун жин тавьдаг юм уу?” хэмээн өрөөн дотуур хий нааш цааш холхино. Аз болоход эцэг нь ажилдаа хараахан яваагүй байсан учир хэрэг бишдсэнийг гадарлаж, жин тавихыг хориглоод “түргэн тусламжийн” тэрэг дуудья гэжээ.

“Түргэн тусламжийн” тэрэг эмнэлэг рүү гарцаагүй аваад явна, гэтэл мань хүн өнөө орой “Красная стрела” хэмээх буухиа галт тэргээр Ленинград руу, Запорожец дарга руу явах ёстой, эмнэлэг гаргахгүй байж мэднэ, тэгвэл Ленинград явах хөг өнгөрч дахиад л Дьяковын хормойноос чирэгдэх болно гэж бодоод Юра “түргэн” дуудахаас дургүйцэв.

-Аль вэ, утасных нь дугаарыг өгөөд орхи гэж эцэг нь зүтгэв.

-Утасдах хэрэггүй ээ, одоохон гайгүй болно.

-Чи танай “түргэний” утсыг өгөхүй юм бол хотынхыг дуудлаа шүү.

Юра орон дээрээ суух гэж үзсэн боловч чадалгүй орь дуу тавин дэрээ тэврэн эвхрэв. Үгүй ээ, тэсэхийн арга алга, “түргэн” ирвэл үгүйдээн тариа хийж өвчнийг нь намдаах байх. Тэрээр

ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВГЭР БАЙДАГ ГАЗРАА ЗААВ.

Эцэг нь дугаарыг олж утасдав. Хагас цагийн дараа машин ирж, Юраг дамнуургаар дамжлан гарахад байшин, орцныхон тэр чигээрээ гайхан мэлэрцгээжээ. Варсонофьевийн гудамжин дахь Дотоод Явдлын Ардын Комиссарын газрын эмнэлэгт авчирсан даруй шууд ширээн дээр хэвгүүлж мэс засал хийгээд, оёогоо арваад хоногийн дараа авна гэжээ. Ингээд балардаг байж! Ленинград явах ажил өнгөрөх нь тэр! Тэгэхэд яаж харамсаж, яаж гутарлаа, гэтэл мухар олгой нь түүнийг аварсан хэрэг байжээ. Ингэхээр чинь хувь заяанд яаж итгэхгүй байх юм бэ!

Мэс засал хийсэн профессор Цифронблат,

-Таны аз болоход цаг алдалгүй авчирчээ. Хэрэв дахиад хоёр, гурван цаг өнгөрсөн бол хэвлийн хордлого болох байсан гэж хэлжээ. Энэ профессор бол хамгийн сайн мэс засалч. Сониноос, өрөөсөн хөл нь хиймэл.

Гэтэл хэвлийн хордлогоос аврагдсан нь гол аз биш, Ленинград яваагүй нь чухамхүү аз байсан юмсанж.

Мэс засал хийлгэсний нөгөөдөр нь “Юрочка, бие сайн уу? Юу хэрэгтэй байна, бичээрэй, Лена” гэсэн зурвастай амтат жүрж, бэрсүүт жүрж, алим бүхий боодол жимс түүнд авчирч өгөв.

Юра зурвасаа доош нь буулгалаа. Лена эргэж иржээ! Ямар ч байсан ирж шүү! мань хүн өвчиндөө туйлдан сульдсан ч гэсэн сэтгэл уяран хайлж, бүр хоолой нь зангираад явчихав. Ингээд бодоход бүхнийг уучилсан байхыг үзэхүл хайрын сэтгэл нь хэвээр, хардаж сэрдэхээ больсон хэрэг.

Гэтэл нөгөө сэхээтнүүдийн маяг гэгч нь юм болов уу? гэх эвгүй бодол толгойд зурсхийв. Урьд өмнө нь юу ч тохиолдож байсан бай, ядарсан цагт гар сунгаж анхаарал халамж тавих ёстой гэгцгээдэг биз дээ. Б о л о в с о н хүмүүс тэгж ёсорхдог, тэд чинь чухам б о л о в с о н хүмүүс... Өөр хэн ч эргэж ирээгүй, ганцхан тэр хүүхэн л эргэсэн билээ.

Биеийг нь асууж утасдсан хүн ганц Александр Федорович Вутковский. Гэхдээ тэр дарга нь юм чинь удирдлагад нь байдаг хүнийхээ төлөө санаа тавих нь ёс. Ээж нь, мэдээжийн хэрэг, эргэж тойролгүй яахав, тэр тооцоонд орохгүй. Тэгээд шал дэмий юм авчирсаныг яана гээч, мөн тэнэг толгой шүү, бялуу хайрч ирсэн байгаа юм, юу болдог, юу болдоггүйг үгүйдээн эмчээс асуудаг байгаа даа. Уул нь энд юуны ч хэрэг байхгүй, хоол унд сайн, яаж хооллож ундлахаа ч мэднэ, эрхбиш ДЯАКГ-ын төв эмнэлэг юм чинь... Харин Лена бол жинхэнэ боловсон байдлаар эргэсэн. Амтат жүрж, бэрсүүт жүрж гэдэг чинь идэх юм биш, гурвалжин будаатай бялуутай яаж зүйрлэх билээ, энэ бол анхаарал халамжийн тэмдэг.

Тэглээ ч гэсэн гагцхүү ёс бодсондоо ч ирсэн хэрэг биш л дээ! Өөрийг нь л мартаж чадахгүй байгаа нь тэр. Лена шиг хүүхнүүд мартдаггүй юм. Бас өөр шиг нь харчуулыг мартана гэж байхгүй.

Нэг муу нусгай биш. Эр хүн юм чинь!

Гэхдээ Шарокт энэ удаа өнгөрсөн зун Серебряный бор-д Ленатай анх удаа эвлэрсэн шигээ баярлах, бахархах, хөөрөх сэтгэл төрсөнгүй. Сэтгэл ханах нь ханасан. Тэгээд л тэр. Тэгсэн ч гэсэн аятайхан шүү дээ.

-Хариугий нь бичээрэй гэж сувилагч хүүхэн хэлэв.

-Бичихэд хэцүү байна... Хоёрхон минутаар ч гэсэн ороод гараг л дээ.

-Тасагт оруулж болохгүй. Та босч явдаг болохоороо хонгилд гараад уулзаарай, манай энд эргэлтийнхэн уулздаг багашаархан танхим бий. Одоохондоо тэснэж үз. Хоёр хоногоос таныг босгоно.

Юра Ленагийн зурвасны ар дээр “Леночка, өгүүлсэн юманд чинь баярлалаа. Надад юу ч хэрэггүй, бүх юм байна, санаа зоволтгүй. Чамтай нүүр учирмаар л байх юм. Хоёр хоногоос намайг босч явахыг зөвшөөрнө, тэгээд би гарч уулзамз. Чи ирээрэй...” гэж бичив.

Жаахан бодолхийлснээ “Үнсье” гэж нэмэв.

Хоёр хоногийн дараа Юрад босох зөвшөөрөл өгч, Лена ч мөн тэр өдөр эргэж ирлээ.

Тэр хоёр Верагийн тасгаас холгүй байх бага шиг танхимд уулзац-гаав. Лена цагаан халааз нөмөрч бүчийг нь сул орхижээ. түүний цаанаас цэнхэр костюм, цагаан цамц харагдана. Өндөр өсгийтэй гутлынх нь түрий чийрэг бадриун хөлийг нь жимбийтэл барьжээ. Юрагийн сэтгэлийг энэ хөл байнга гижигддэг бөгөөд эдүгээ сүрчиг-нийх нь тансаг үнэр улам догдлуулна... Гэрэл гийсэн эрүүл саруул энэ сайхан хүүхний дэргэд мань хүн сахлаа ч хусаагүй, нүцгэн хөлдөө тавхай углачихсан, дотуур цагаан хувцсан дээр эмнэлгийн үлхэгэр халааз хэдрээд сууж буй нь хөөрхийлөлтэй.

-Чи намайг танив уу, би ч бараг талийгаач шиг харагдаж байгаа биз дээ? хэмээн Шарок жуумалзах аядав.

-Битгий даваадуул, жаахан цонхигор байна, эмнэлэгт байгаа хүн чинь аргагүй шүү дээ гэж Лена инээмсэглэснээ, -Чамайг энд хэр удаах вэ? гэж асуув.

-Хоёр, гурван долоо хонох байх.

-Гутрах юм юу байхав, би чамайг эргэж байна аа.

Ямар ч байлаа гэсэн сайн хүүхэн шүү! хүнийрхүү ч гэсэн болом-жийн сайхан хүүхэн. Цагаан цайлган, энхрий найланхай амьтан. Харсаар байтал өөрт нь хайртай, одоо дахиад л өөрийнх нь төлөө яахаас ч буцахгүй царайтай, тэгсэн мөртлөө л ямар нэгэн түлхэх цэг байгаад байдаг, иймэрхүү юмыг чинь шинжлэх ухааны хэлээр тэгж хэлдэг билүү дээ.

Энэ хүүхний чухамхүү тэр цайлган сэтгэл, эелдэг наалинхай, шударга шулуун, хэрсүү, ёсорхог зан энэ тэр гээд хайр татам бүх юм нь Шарокийн хувьд үл нийцэх чанар юм. Тэрээр энэ хүүхэнтэй илэн далангүй, яг байдгаараа байж чадахгүй.

Алтан хошуу өргөгч, муу банзал Вика шивэгчин биш өөрийнх нь авгай байсан юм гэж санавал харин түүнтэй илэн далангүй байж чадахсан билээ. Тэр хүүхэнтэй бол илэн далангүй сэтгэл нээн ярьж, ямар ч нэрэлхэх цэрвэх юмгүйгээр элдэв муу муухайгаа уудлан хэлэлцэж болно. Тэгсэн байхад ойлгоод зогсохгүй нэмэрт нь сайхан зөвлөгөө өгөх байсан бий.

Гэтэл Ленатай тэгж болохгүй. Ёс зүй, зан суртахууны тухай түүний ойлголт төсөөлөлд зохицох хэрэгтэй. Гэтэл өөрийнх нь эрхэлдэг ажил дээр ямар юмных нь ёс зүй, зан суртахуун байх вэ дээ, ер нь тийм юм гэж байдаг ч юм уу, үгүй ч юм уу?

Ленагийн эцэг эрхэм хүндэт Иван Григорьевич Будягин ямар ёс зүй, зан суртахуунтай билээ? Тэрээр мужийн онцгой комиссын дарга байхдаа хичнээн хүнийг бүрэлгэсэн билээ? хүн амьтныг өөр ертөнц рүү тонилгож байхдаа ямар ёс зүй, зан суртахууныг удирдлага болгож байсан бол? Пролетарийн сонирхлыг уу? Тэгвэл хэн тэр сонирхлыг чинь тодорхойлсон юм бэ? Нам уу? Ленин үү?

Болж байгаа хэрэг. Тэгвэл мань Шарок ч гэсэн бас л пролетарийн сонирхлыг удирдлага болгож байгаа. Ганц ялгаа нь гэвэл тэр сонирхлыг өнөөгийн намын удирдагч нөхөр Сталин л тодорхойлж байна. Гэтэл энэ бүхнийг Ленад тайлбарлаад ямар ч утга байхгүй. Хүмүүсийн тухай ярья гэвэл яг түүн шиг хүндэтгэлтэй ярих хэрэгтэй, мөрдөгдөж байгаа хүмүүсийн тухайд бол бас л түүн шиг өрөвдөлтэй ярих хэрэгтэй. мань хүн нэг удаа нэг юмны тухай түс тас хэлчихсэн чинь хүүхэн зөрөөгүй хэрнээ жигтэйхэн эмээсэн царай гаргаж, хамаг урам хугалчихсан билээ.

Хөнжилд байхад бол цоргисон халуун биетэй, соронзон мэт татах увьдастай салж хагацахын аргагүй, хүний аяар хүүхэн. Энэ бүхэн тийм нь тийм, гэхдээ хэн нэгэнтэй сэтгэлээ уудлан ярих хэрэгтэй шүү дээ... Энэ хүүхэн өдөр болгон эмнэлэг рүү салгалж ирлээ гээд ямар нэмэр байх вэ?

Уул нь мань хүн санаа зовоож байгаа бүхнийг сэтгэлээ онгойтол яривал юу шиг байх вэ дээ. Ленинград явж чадаагүй тухай ханиндаа жаал халаглан, өөрийнх нь оронд Зопорожецийн багт тэднийхний хэн нь очсон байж болохыг баримжаалж ярилцахгүй юу. хэн явсныг эмнэлгээс гарангуут мэдээд авах нь зайлшгүй. Гэтэл Дьяков заль гаргаад, явсан хүний нэрийг хэлэхгүй байж мэднэ... Эсвэл яаралтай хэрэг биш байсан бол Запорожец Москва руу “Надад Шарокоос өөр хүн хэрэггүй” гэж хэлээд өөрийг нь хүлээж байх ч юм бил үү.

Энэ бүхний оронд ингэж өөрт ямар ч сонирхолгүй шал дэмий юм чалчин суух ч гэж дээ. Тэрээр юу бодож байгаагаа ч ярьж чаддаггүй, яаж бодож байгаагаа ч ярьж чаддаггүй, гагцхүү хүүхний аяыг дагаж, буруу үг хэлчих вий, айсан харцтай нь тулгарчих вий хэмээн байнга биеэ барин хавчигнаж, өөрийгөө доромжилж зовоож сууна. Тэгсэн мөртлөө яриагаа тасалмааргүй санагдана...

Шарок эмнэлгээс гарч тэр хоёр дахиад хаа нэгтээ уулзацгаадаг боллоо.

Юра шөнийн ажилтай, Лена өдрийн ажилтай. түүнээс гадна уулзах газар ч байхгүй. Дьяковын нөгөө нэг байранд уулзалтай нь биш, Викатай мөргөлдүүлж баларсан маань болоо.

Тэр хоёр Серебряный бор руу Ленагийн зуслангийн байранд хоёр удаа очжээ. Байр нь өвөл галлагаатай болохоор бүтэн сайнд хэн нэг хүн заавал ирнэ, оюутны өвлийн амралтаар Владлен цанаар гулгах гээд тийшээ ирээд бүр суурьшчихна.

Юра нэг удаа орой ажил дээрээсээ утасдав. Хүүхэн баярлан дуу шуу болж ажил явдлынх нь тухай асуув.

-Нэг муу нохойн гөлөгтэй орооцолдчихсон чинь ер салах юм биш, сүг болтлоо ядраад байна.

Хүүхэн, мэдээж, тэр дороо дуугаа хураачих нь тэр. Ариухан амьтан. Гүнжтэн. Үгүй ер, болохгүй юм хэлчихэж гэнэ, тийм үг тэднийхний ой ухаанд багтахгүй байх нь. Эцэх цуцах нь эцэстээ хүрчихсэн хүн яаж үг болгоноо цэнэж чадах билээ.

-За, тэр яахав, манай явдлыг бүү бод. Өөрийнх чинь ямар байна?

-Минийх гайгүй ээ, хуучин янзаараа л байна.

-Би зүгээр л утасдсан юм, ойрд чиний дууг сонссонгүй. Майн баярыг яаж өнгөрөөцгөөх вэ? гэж Шарок асуув.

-Чи хэдэн хоног сул байх юм бэ?

-Хоёр хоног.

-Би ч бас хоёр өдөр сул. Нэг тийшээ явцгаах уу?

-Хаашаа?

-Бодъё л доо... Гурван долоо хоногийн зай байна.

-За тэгье, бодоцгооё гэж Шарок өгүүлэв.

Жаргалдаа ташуурам хоёр өдөр заяажээ. Тэр хоёр Москвагийн хаяа дүүрэгт байх эрдэм шинжилгээний ажилтан нарын хаалттай сувилалын газар тусгай автобусаар ирцгээв.

-Тасалбар яаж олоо вэ? гэж Юра асуув.

-Ямар хамаа байна гэж Лена зувчуулан хариулав.

Гэвч Лена тасалбаруудаа амралтын эрхлэгчид шалгуулж байхад Будягины нэр дээр бичигдсэн байгааг Юра олж харжээ. Аав нь хонгор охиныхоо төлөө санаа тавьсан нь тэр.

Амралтын байшин тун дэгжин. Юрад зүс үзсэн хүн нэг ч алга, харин Лена олон хүнтэй танимгайрхан мэндэлж байв. Хэд хэдэн танилынхаа нэрийг Юрад хэлж өглөө. Тэд нар нь эрдэмтэд, зарим нь академичид гэнэ. Майн баярын хоёр өдрийг өнгөрүүлэхээр авгай хүүхдүүдтэйгээ ирцгээсэн ажээ.

Тэр хоёрт цонх нь хусан төгөл рүү харсан жижгэвтэр өрөө оногджээ. Модны мөчир одоо хэр нүцгэн боловч бүхэлдээ цайвар ногоон туяа цохиж, гөлөглөн бүхий нь юу юугүй нахиалах гэж буй хэрэг.

-Хусны гол хавар л ийм цагаан байдаг юм, чи анзаардаг уу? гээд Лена Юра руу харав.

Цаадах нь үүнийг анзаарч байсангүй.

-Би гэдэг хүн хэзээ хамгийн сүүлд хотоос гадагш гарснаа ч санахгүй байна.

Ноднингийн унамал навчны цаанаас нялх ногоо соёолон сэрвий-жээ. Энэ үес тэнгэр сайхан, нарлаг дулаахан байгаа ч газар сэвэрч гүйцээгүй, зам зөрөг чийгтэй, явахад шал шалхийнэ. Гадуур хувцастай хүн нэг ч үгүй, цөм костюмтай. Тордлого сайтай, биерхүү сайхан хүүхнүүд даашинзныхаа ханцуйг эргүүлсэн харагдана.

Гар бөмбөг бас крокет тоглоцгооно. Шарок крокетийг анх удаа харж байгаа нь энэ. Хуучин цагийн тоглоом. Мундаг академичид, тэдний бордмол авгай нар бөмбөгөнд хүрсэн хүрээгүй, хаалганд орсон ороогүй гэлцэн Юрад үл ойлгогдох дүрэмнээс болж үнэн санаанаасаа улайран маргалдаж байгаа нь инээдэмтэй. Сонирхож байгаа хүмүүс хөндлөнгөөс тэдний маргаанд оролцоход цаадуул нь тоглоомонд битгий садаа болооч гэж эелдэг ч гэсэн эрсхэн шаардана.

Ер нь крокетийн талбай дээр хэрдээ зугаатай байлаа. Юра Ленагийн тоглохыг харж, тэдний харц мөргөлдвөл урамшуулан инээмсэглэнэ. Нүсэр биетэй, болхи хөдөлгөөнтэй, харах царайнаасаа спортод хавирамгүй баймаар атал Лена Серебряный бор-д байхад усанд сайхан сэлж байсныг Юра харсан, энд бас крокет, гар бөмбөгний аль алиныг яггүй тоглож байх юм. Овоо шүү, тамирчин хүүхэн байх нь. Лена хөгжин тайвширч, нүд нь гялалзан Юрад халамжтай өөриймсөг байлаа.

Тэд нар хоёрдахь өдрийхнөө орой тийш буцах ёстой ажээ. Үдийн хоолны дараа хажуулцгаав... Тэгээд босохын цагт Лена цаадахынхаа гарыг дэрлэн хэвтэж байснаа,

-Энд аятайхан байлаа шүү, тийм үү? гэж асуухад Юра,

-Тийм ээ, боломжийн л байлаа гэж зүүрмэглэн хариулав.

-Юра, чи бид хоёр ингээд салцгааж байна шүү дээ гэж Лена намуухан өгүүлэв. Тэгж хэлээд инээмсэглэх шиг Юрад санагдав.

мань хүн саяны хэлсэн зүйлийн утгыг тэр даруйдаа ойлгосонгүй.

-Юу гэнэв?

-Чи бид хоёр салцгааж байна гэж би хэлсэн юм. Энэ удаа бол үүрд салах нь.

-Гэнэтхэн яачих нь тэр билээ?

-Гэнэтхэн биш ээ. Би өнөөдөр ингэж шийдэж байгаа юм биш. Харин би чамтай аятайхан салъя, болж өгвөл аз жаргалтай салъя гэж бодсон юм.

-Тэгээд ийш нь авчраа юу?

-Тэгээд ийш нь авчирсан юм.

-За тэгдэг байж. Мөн сайхан цэвэрхэн хийж байна шүү. Дээд зэргээр. Хатантан гуай нууц янагаа зайлуулж байна гэлтэй. Тэгсэн ч гэсэн шалтгааныг нь мэдмээр байх юм.

-Шалтгааныг уу? гэснээ Лена гэдрэгээ харан хоёр гараа дэрлээд, -Шалтгааныг хэлэх хэрэг байх уу даа... Чи бид хоёр ямар хүүхдүүд биш, сэтгэл алдсан залуу хосууд биш. Утсаар дуудаж уулздаг ийм болзоо чи бид хоёрт зохихгүй... Амьдралаа холбох тухай ярьж байгаа юм биш шүү, тэгж сануузай гэв.

-Яагаад тэгж болохгүй билээ? Би чамтай суух санаатай ч юм бил үү?

Лена инээд алдав.

-Юрочка минь, тэр чинь арай багадана... Чи санаатай байж болно. Гэтэл би тийм санаагүй байж болно биз дээ.

Ерөөс яривал Юра түүнтэй суух бодолгүй билээ. Суух тухай ярина гэдэг бол инээдэм. Гэтэл мань хүний гозонг хөдөлгөж, доромжилсон тул ярихаас яахав.

-Би чамд юугаараа тохирохгүй байгаасан билээ?

-Чи надад тохирно, би ч бас чамд тохирч байна гэхэд болох байх. Гэхдээ эндшээ, энэ орон дээр юм уу, ер нь өөр аль нэг орон дээр л тохирч байна. Гэтэл ор гэдэг чинь амьдрал хараахан биш.

-Чи чинь юу вэ, дахиад л Викатай хардаад эхлэв үү?

-Би чамайг Викатай хардсан гэж чи яаж мэдээ вэ? Би тэр талын юм чамд дурсаагүй шүү.

-Чи яриагүй нь яриагүй, гэхдээ би мэдэж байна, б и б ү х ю м ы г м э д э ж б а й х ё с т о й х ү н. Шарок энэ үгийг хэрэгтэй хэрэггүй газар шургуулах дуртай л даа.

-Тэгж ярих юм бол би ч мэднэ. Вика тэр байранд хэн болж, яах гэж ирснийг би мэднэ.

Юра тохой дээрээ өндийв. Цаанаа л нэг биш, нэг л ёозгүй юмны үнэр гараад байх шиг. мань хүн зүгээр л хүүхний хардах сэтгэл арилж дээ гэж бодож байсан чинь цаадах нь болохоор Вика шивэгчин гэдгийг мэдэж байх нь. Яагаад мэдчих вэ? Вика өөрөө хэлчихээгүй байгаа? Тэгсэн бол мань эр нэг нээнтэгтэй болсон хэрэг.

-Вика хэн болж над руу ирсэн байх нь вэ?

-Би энэ сэдвээр ярихыг хүсэхгүй байна.

Хүүхний дууны өнгөнд будягиныхны зөрүүд зан данхийгээд явчихыг мань эр мэдэрлээ.

-Энэ сэдэв надад сонин биш байна. Вика гэж хэн болохыг олон хүн мэднэ. Харин тэр ажлаараа чамтай холбоотой гэдгийг ганцхан би л мэднэ. Энэ бол надаас гадагш гараагүй. Тийм учраас чи бүү санаа зов. Би хэзээ ч, ямар ч нөхцөлд чамд ямар нэгэн хор хүргэхгүй. Чи үүнийг маш сайн мэдэж байгаа. Викаг чамтай байхыг хараад миний дургүй буцалж, харьцаагаа тасалсан нь үнэн. Харин дараа нь өөрийнхөө буруу байсныг би ойлгосон. Тийм учраас тэр явдал бол одоо ямар ч холбогдол байхгүй. Яагаад чи бид хоёр салж байна вэ? Би уул нь хэлэхгүй гэж бодсон юм, чи заавал хэлүүлмээр байгаа бол хэлье л дээ. Юра, би дахиад жирэмсэлчихсэн. Би хүүхдээ гаргана. Үрээ зулбуулах юм уу, хөндүүлэх гэж дахиад яасан ч оролдохгүй гэдгийг чи эрхбиш гадарлаж байгаа байх. Би хүү юм уу, охинтой болно. Чамайг юунд ч албадахгүй. Чамаас хүүхдийн тэтгэлэг нэхэхгүй, эцэг нь гэж чамаар овоглохгүй, чиний дургүй гэдгийг би мэднэ.

Мөн догь сонин оо!

Гэхдээ Юра энэ мэдээг сонссондоо биш, хүүхний тэр тогтуухан хэрнээ эзэрхэг шинэ дууг сонссондоо л бүр гайхаж хоцорчээ.

-Ингэж ярихад, яагаад?.. хэмээн Шарок эхлэх гэтэл цаадах нь тасдан,

-Чи битгий зөр! Чи бидний ярьж байгаа юм бол худлаа сайхан үг ярих дөгөө болох учиргүй гэв.

Хүүхэн дуугаа чангалаагүй ч гэсэн нөгөө л будягиныхны эрс тэрс зан дахиад тодхон сонсдов.

-Бид ханилах нь чи бид хоёрын хэнд ч хэрэггүй, ялангуяа чамд хэрэггүй, худлаа дүр эсгэж байхын хэрэг юу байна?

Шарок босч цонх руу очиж урт хөшгийг ярнаа нэг хэсэг зогсов.

Зүйтэй л дээ. мань хүн ч хүүхэнд хэрэггүй, хүүхэн ч өөрт нь хэрэггүй. хүний айлд хүргэн орж, хэзээ үргэлжид сэтгэл амар заяа үзэхгүй, тэр айлынхны ая занг харж, үг болгоноо цэгнэж аж төрнө гэж байж болшгүй зүйл.

Ийнхүү цонхны дэргэд зогсохдоо бодсон зүйлийг нь Лена бараг үг алдалгүй давтах мэт өгүүлэхэд Шарок ёстой мэл гайхаж цэл хөхрөв. Харваас, түүнийг дутуу үнэлж байж дээ.

-Юра, чи бид нар бол хүний улс, үзэл бодол ч өөр, эрхэмлэдэг зүйлс ч өөр, бие биенийхээ учрыг зовж байж олж байна. Чи миний аяыг харж байна, бодож байгаагаасаа шал өөр юм ярьж байна, чиний ярьж байгаа юм чинь хэрэг дээрээ бол шал өөр байна, энэ бүхэн надад илт байна. Ингэж байх зовлонтой юм, наад зах нь яршигтай юм.

-Чи юу хэлэх гээд байна вэ?

-Сашагийн тухай чиний ярьсныг л хэлж байна. Чиний ачаар хорих ялны оронд дөнгөж гурван жилийн цөллөг оногдсон гэснийг чинь. Бас түүний баривчлагдсан нь чамд гай болох юм шиг ярьсныг чинь. Донгодов оо! Би л дандаа чамайг сайнаар ойлгох гэсэндээ ярьсан бүхэнд чинь өөрийгөө итгүүлж үнэмшиж явсан хэрэг.

Шарок дуугарсангүй,

-Бас нөгөө Викагийн явдал. Элдэв муу юмыг ингэж нэг саванд хольж хутгана гэдэг бол үнэхээр шижээргүй хэрэг.

Шарок хүүхний хажууд орон дээр зэрэгцэн сууж гарыг нь атган инээмсэглээд,

-Чи тэгвэл яах гэж намайг эмнэлэгт эргэж ирсэн юм бэ? Бидний харилцааг чи өөрөө л сэргээсэн шүү дээ гэв.

-Би яаж очихгүй байх билээ... Санаа зовоод байсан юм. Чамайг “Дамнуургаар дамжилж гаргаад түргэн тусламжийн тэргээр аваад явчихсан” гэж Нина надад хэлсэн. Эмнэлэгт хэвтэж байхад хэн ч эргэж ирэхгүй бол үнэхээр ганцаардмал хөөрхий байдаг болохоор би чамайг бас өрөвдсөн юм.

-Аа, тийм бий... Тэгвэл чи намайг зүгээр л өрөвдсөн байх нь. Гэтэл би гэдэг хүн чамайг надад сэтгэлтэй гэж найдаж явсныг яана.

-Би чамд уу?.. Мэдэхгүй. Юу л бол... Гэхдээ миний хувьд чамтай нөхөр ёсоор салмаар байна. Чухамхүү ийм хавар цагийн баярын тунгалаг сайхан өдөр салмаар байна. Энэ өдөр чухамхүү тийм байдлаар сэтгэлд үлдээсэй гэж хүсч байна.

Эмнэлгийн тухай ярих хэрэггүй байж. Шал дэмий өөрийгөө бас нэг доромжлуулчихлаа, бас л нөгөө сэхээтнийхээ боловсон занг харуулж байна. мань хүн бол түүнийг эмнэлэгт байхад эргэж очоогүй. Лена тэгэхэд зүгээр ч үгүй өөрийнх нь буруугаас болж үхэх гэж байсан шүү дээ. Гэтэл өөрийг нь нэг муу яль бүлхэн мэс засал хийлгэсний төлөө эргэж тойрч, өөрөөс нь дээр хүн гэдгээ харуулсан байх нь.

Одоо ч гэсэн дээ. Жирэмсэлчихээд байгаа хэрнээ дахиад л хамаг бурууг өөрөө авч, мань хүнийг элдэв хариуцлага, сэтгэлийн зовлон, хүүхдийн тэтгэлэг сэлтээс ангижруулж байна. Аягүй бол халуун бүл дотроо амьхнаараа аль хэдийн ярьцгаачихаа биз. Аягүй бол Иван Григорьевич өөрөө “Хүүхдээ гарга, чиний тэр муу увайгүй хартай харгүй болно!” гэж хэлээ байлгүй. Дахиад л тэд нүүс бол язгууртнууд, мань хүн бол өчүүхэн барлаг гэдгийг үзүүлж өгч байх нь.

Ингэхээр мань хүн хүүхэнд хариу тавих ёстой, энэ байдлаас нэр төртэй гарах хэрэгтэй.

-Биднүүс энэ хоёр хоногийг ёстой сайхан өнгөрөөлөө. Харилцаагаа ийм тийм гэж тунирхан сайхан амралтыг хиртээхээ больцгооё. Би чамайг ойлгож байна. Ийм юм ярих гэж зэхсэн учраас чи яльгүй ч гэсэн шар хөөрсөн байх, одоо хоюул ийм яриагаар яах вэ, чамд энэ байдлаасаа гарахад хэцүү. Эндээс явцгаая, чиний сэтгэл тайвшраг, тэгээд эргээд энэ тухай

ярьж болно шүү дээ.

Лена толгой сэгсрэв.

-Энэ тухай чи бид хоёр хэзээ ч дахиж ярихгүй. Бид хэзээ ч дахиад уулзахгүй, ингээд бүх юм дуусах нь энэ, Юра.

Тэрээр ширээн дээрээс цагаа авч зүүгээд босч хувцаслах зуур,

-Өнөөдөр хоёр автобустай. Нэг нь долоод, нөгөө нь наймд. Би эртхэн харья гэж бодоод долоон цагийнхад бичүүлчихсэн. Долоод явах хүмүүс хагас цагийн өмнө хоолондоо орох ёстой. Тэгэхээр шуурхайлна шүү, Юрочка минь! гэж огт юу ч болоогүй мэт өгүүлэв.

Варя барилгын дээд сургуульд оржээ. Нина өдрийн ангид ор гэж зөвлөсөн боловч тэтгэлэг бага учраас түүний гарыг харах хэрэг гарна хэмээн үгэнд нь оролгүй оройн ангид орсон ажээ.

Тэтгэлэг бага гэдэг шалтгийг Нина төдий л ойшоосонгүй. Сая сая оюутан болоод л байгаа юм чинь. Мэдээж, даруухан л амь зуухаас өөр аргагүй болох байсан л даа. Гэхдээ хэн янгүй л даруухан аж төрцгөөж байгаа. Одоо тийм цаг. Улс орон хамаг хүчээ хөвчлөн дайчилж хүчирхэг социалист гүрнийг цогцлон байгуулж байна. Энэ аугаа их зорилгын төлөөнөө ард түмэн эцсийн өнчин ишгээ золиослон, дутах гуцахын бэрх гачланд нэрвэгдэж, Варягийн үе тэнгийнхэн шороон гэр, модон пинд бээрэн хоног төөрүүлж үйлдвэр, завод, цахилгаан станц барьцгааж байна. Оюутнууд ч гэсэн зургаа зургаагаараа нэг өрөөнд чихцэлдэж, оюутны хямд гуанзангаар өл хоол залгацгааж байна. Гэтэл Варя Арбатад нэг өрөө байртай төдийгүй, хуучин нөхөр шүү юм нь хэдийвээр мөрийтэй тоглоомны луйварчин ч гэсэн түүнийг эрхбиш таван жилээр өрсөөд хувцас хунараар тордчихсон учир өдрийн ангид ямар ч зовлон гачаалгүй суралцвал суралцмаар.

Ер нь бол ч Нина түүний оройн ангид сурахыг эсэргүүцсэн хэрэг бус. Гэхдээ худлаа бачлаж хов живэнд өртөж байхын хэрэг юу байна? гэж боджээ. Төрсөн дүүгээ мэдэхгүйсэн бил үү?.. Мэдэхийн цаагуур мэднэ! Оройн ангид орсны учрыг ч мэдэж цөхөх юм байхгүй. Сургуульд байгаа гэдгээр ажлын газрынхаа олон нийтийн наад захын ажлаас чөлөөлөгдөнө, ажил хийдэг гэдгээр сургуулийнхаа олон нийтийн үүргээс чөлөөлөгдөнө. Өөрөө юу гэж үнэнээ хэлсэн билээ дээ? “Ээ, бурхны аврал гэж, одоо хуралд явах аюулаас саллаа. Дуртайгаараа надаас бусад нь л гараа өргөж гозолзуулж “суут мэргэнээ” магтан шагшиж, дуу алдацгааж байг, муусайн маанагууд”. Намын гишүүн хүнд, эгчдээ ингэж хэлж байгаа юм шүү дээ! Варятай маргаж, ямар нэгэн юм үнэмшүүлж батлана гэж санасны гарз. түүний насан дээр ийм тэрсүүд, ийм хорсолтой байна гэхэд ёстой гайхмаар!

Орныхоо дээр Саша Панкратовын зургийг хадчихсан байхыг яана. Ердийн хэмжээний тийм зураг Нинагийн зургийн цомогт бий л дээ. Гэтэл энэ нь шилтэй жаазанд хийсэн том зураг. Зориуд аятайхан газар хадсан байгаа юм. Нинагийн хувьд ширээнийх нь дээд талд нөхөр Сталины хөрөг байдаг бол Варягийн хувьд “хувьсгалын эсэргүү ухуулга, суртал нэвтрүүлэг” хэмээх 58-ын 10 гэдэг зүйл ангиар Сибирьт цөлөгдсөн Саша Панкратовын зураг байгаа нь тэр. Нина дээр орж гарсан хүн Сашагийн зургийг танина, айл хөршийнхөн орж ирсэн ч бас л танина, гэтэл хөрш авгай Вера Станиславовна гэхэд л ямаршуухан шулам билээ! Харчихаад “жогтой” инээмсэглэж байсан, лав алтан хошуу өргөнө. Ингэлээ гээд өрөөндөө амьтан хүн оруулахаа байлтай биш дээ?

-Чи яах гэж Сашагийн зургийг хадсан юм бэ? гэж Нина асуув.

-Чи юунд нь санаа зовоо вэ?

-Чи бид хоёр чинь ямар ч атугай нэг өрөөнд аж төрж байгаа улс хойно нэг нь нөгөөгөө эрхбиш бодох ёстой байлгүй.

-Чи манай энэ хамгийн сайн машинчийн зургийг хадахдаа надаас асуусан бил үү? гээд Варя Сталины хөрөг рүү заав. Нина эхлээд ойлгохгүй,

-Яахаараа машинч байдаг билээ? гэв.

-Яах юу байхав. Төмөр замчид манай хамгийн сайн машинч Сталин гэж бичдэг шүү дээ.

-Тэгж ярьж хэрхэвч болохгүй! Ойлгов уу? Болохгүй! Чамайг нөхөр шүү юмтайгаа нөхцчихөөд энд сураггүй байхад чинь би энэ хөргийг хадсан юм. Би нөхөр Сталиныг хүндэтгэдэг.

-Би нөхөр Панкратовыг хүндэтгэдэг гэж Варя гудиггүй өчив.

-хүндлэх юм бол хүндэлж л бай, харин амьхандаа л тэгж байвал барав... Нийтийн өмнө дэлгээд байхын хэрэг байхгүй! Тэр чиний юу чинь юм бэ? Нөхөр чинь үү? Чамд өөр нөхөр байсан биш бил үү? Сүйт хархүү чинь үү? Тэгвэл түүнийгээ хүлээхгүй юу гээд нэг муу луйварчингаас зүүгдчихсэн юм? Сургуулийн нөхөр үү? Чи сургуульд байхдаа түүнийг огт мэддэггүй байсан. Тэр бол чиний юу ч биш! Юу ч биш! Юу боллоо гэж түүний зургийг өлгөж байгаа юм? Зориуд дэлгэж байгаа юм уу? Тэгвэл энэ чинь юугаар дуусч болохыг бодохгүй байна уу? Сайхан мэдээрэй, би чамд эртхэн хэлчихье. Чи өөрөө энэ зургийг буулгахгүй юм бол би аваад хаячихана шүү.

-Өө, тэгдэг юм уу... хэмээн Варя түгдэрсхийснээ, -Чамайг Сашагийн зурагт гар хүрэх юм бол би чиний энэ сахалтыг хонгилд гаргаад бүхний нүдэн дээр урж хаяна гэж мэдээрэй. Эргэлзэхийн хэрэггүй шүү гэж тайван эрсхэн хэлэв.

Нинагийн уур дүрсхийн шатах нь тэр. Муу солиот, завхай яатуу! Сашаг шүтээн болгож гэнэ, үгүй ер, яасан сайхан тэнгэрлэг дээдэс вэ! Ёстой дөргүй бух! Энэ муугийн ярьж хэлж байгаа юмны ганцхан хувьд гэхэд л таван жилийн ял онооход болохгүй гэх газар алга. Бас Нинад ч давхар хариуцлага оногдоно. Тэгэхдээ хүрвэл юугаа хэлж, хуйхаа маажих вэ? Төрсөн дүүгийнхээ санаа сэтгэлийг мэдэхгүй байсан гэх үү? Нэг дор цуг амьдарч байгаад тэр үү?

-Чи надтай ингэж бүү ярь! Би хэрхэвч зөвшөөрөхгүй! гэж Нина эрсхэн хэлэв.

-Би ерөөсөө дуугарахаа больдог юм бил үү?

-Тэг, өөр ярих юм олдохгүй байгаа бол дуугай байж бай. Би коммунист учраас зөвлөлтийн эсрэг юм сонсож байхыг хүсэхгүй байна.

-Зөвлөлтийн эсрэг ий? Чамд би Зөвлөлт засгийн эсрэг аль нэг юм хэлсэн гэж үү дээ? Би бол Зөвлөлт засгийн төлөө хүн, харин танай тэр “эцэг, багш”-ийг чинь нэг нүдээр үзэхгүй!

-Нөхөр Сталиныг хэн гэнэ ээ чи, бүү донгос! Нөхөр Сталин, Зөвлөлт засаг хоёр бол нэг зүйл.

-Чамд л нэг зүйл байх.

-Зөвхөн надад биш, манай нам, нийт ард түмний хувьд нэг зүйл.

-Чи бүх ард түмний өмнөөс бүү ярь, та нар ард түмнийг сайн мунхруулж байгаа шүү. Нэг сонинд “Енукизег Бүх Кавказын удирдагчаар сонгохын тулд түүнийг сулла” гэж бичсэн. Гэтэл бусад сонинд “Улс төр, ахуйн талаар завхралд орсон учир намаас хөө” гэж бичиж байна. Та нар алхам тутамдаа худлаа залцгааж байна!

Хонгилд хөлийн чимээ гарснаа тэдний үүдэн тус ирээд нам гүм болчихов. За, хэлээгүй юу тэр, одоо Сашагийн зурагнаас болоод энэ хоёрын яриаг нөгөө өлөгчин Вера Станиславовна чагнаад салахаа байх нь.

-Дахиад хэлэхэд, чи надтай ийм юм бүү ярь, ойлгож байна уу? хэмээн Нина шивнээд, нүүр нь улалзан гараа хий зангаж, -Бүү ярь! Ерөөсөө надтай ч биш, хэнтэй ч байсан ийм юм бүү ярьж бай! гэв. Варя бас дуугаа намсган,

-Чамтай ярихгүй байж чадна, бусадтай яах нь миний хэрэг. Битгий гараа савчаад бай! гэв.

-Ингээд байвал юугаар төгсөж болохыг ойлгож байна уу?

-Юугаар ч дуусахгүй. Би гагцхүү хүн шиг л хүнтэй ярьдаг юм чинь.

-Дур чинь мэдэг. Харин чи м и н и й д э р г э д дахиад иймэрхүү амьсгаатай юм яривал бид хоёрын хэн нэг нь энэ байрнаас үүрд явахад хүрнэ гэж мэдээрэй.

-Би чамайг аргамжаагүй шүү хэмээн Варя хямсайснаа, -Гэвч... чи намайг Бутыркийн шорон руу гулгуулж дөнгөнө биз гэв.

-Чамайг буруугаа ухаарахгүй бол тэгэхээс өөр аргагүй болж ч магадгүй л байх.

-За яахав, тэгж гэмээ нь ч и н и й х у в ь д тун ойлгомжтой зүй ёсны хэрэг болох юм. Харин эргэх гэж нэг лай гарцаагүй ирэх вий гэж Варя хэнэггүй өгүүлэв.

Тэгснээ,

Мөсөөр бүү яв

Мөс цөмөрчихнө

Хулгайчийг бүү хайрла

Хулгайч баригдчихна

Хулгайч баригдчихвал

Шоронд орчихно

Шоронгийн хүн эргэх

Шохоорхох ажил биш... хэмээн дуулж гарав.

-Битгий солиорч муу ёрол! гэж Нина зандрав.

-Харин чи ч эргэж ирэхгүй л дээ, нэг муу зөвлөлтийн эсрэг үзэлтнийг эргээд байхдаа яахав дээ. Өөр хүмүүс эргэнэ. За, тэр яахав гээд Варя босч, -Чи бүү санаа зов, дахиад ийм сэдвээр би чамтай ярихгүй гэж хэлэв.

Тэр хоёр зөвхөн энэ сэдвээр төдийгүй ерөөсөө юм ярихаа болив. Юун тухай ч ярих вэ дээ? Дор дороо л амиа борлуулцгааж яваа хойно.

Гэвч ингэлээ гээд Нинагийн сэтгэл амарсангүй. Хариуцлагатай, хатуу ширүүн цаг үе. Гадаадын дайсанд хүрээлэгдсэн эх орон дотоодынхоо дайсантай тэмцэж байна. Сталинд өчүүхэн төдий эргэлзэнэ гэдэг бол намд эргэлзсэн, социализмын үйл хэрэгт үл итгэсэн хэрэг. Гагцхүү хязгааргүй, өө сэвгүй итгэл л сая сая хүнийг шинэ нийгэм байгуулах үйл хэргийн төлөө нэгтгэж чадна. Гагцхүү хязгааргүй, өө сэвгүй итгэл л ялалтыг хангаж чадна. Байлдаанд орсон хүн ярих биш байлдах ёстой, удирдлагын тушаалыг хэлэлцэх биш биелүүлэх ёстой. Нинагийн хувьд, зөвлөлтийн сая сая хүний хувьд эрхэм нандин бүх зүйлсэд дүү нь эргэлзэх төдийгүй үл итгэж байна. Эхлээд бандь нар, бүжиг танц, гуанз ресторан гэж хэсэг харайлгасан, дараа нь хар хүн гэж нэг муу хулгайч, луйварчин, мөрийчинтэй толгой холбосон, одоо зөвлөлтийн эсрэг үзэлд автжээ. Энэ бүхэн юунд хүргэх вэ? Варяг юу хүлээж байна? Бас Нинаг өөрийг нь юу хүлээж байна? Энэ бол айдасны тухай асуудал бус, намч шударга ёсны тухай асуулал. Тэрээр Варяг хаацайлснаар зөвлөлтийн эсрэг үг яриаг өөгшүүлж, тэгснээрээ зөвлөлтийн эсрэг үзлийг өөгшүүлж байна гэсэн үг. Ийнхүү намын өмнө гэмт хэрэг үйлдэж х а м с а а т а н болж байна гэсэн үг.

Гэхдээ яах вэ? Варягийн дарга дээр очиж ярилцах уу? Намын байгууллагад нь мэдэгдэх үү? Дүүгээ ховлох хэрэг үү?! Тийм муухай юм гэж хаа байхав! Тэгэх юм бол Варя шоронд орж, эгч нь хийлгэчихсэн юм гэнэ лээ гээд хүмүүс толгой дараалан шуугчихна. Гэтэл дуугүй байж бас болохгүй.

Алевтина Федоровнатай зөвлөж ярих уу? Алевтина Федоровна өөртэй нь хэзээ ямагт ээж шиг нь харьцдаг юм чинь. Тэрээр Нинад хайртай, түүнийг комсомолын гишүүн, идэвхтэн хэмээн талархдаг хүн. Нинаг сурганы дээд сургууль төгсөхөд нь хөдөө хөөгдөх аюулаас аварч, сургуульдаа түүхийн багшаар авсан. Нина Саша Панкратовыг баригдсантай холбогдуулан өргөдөл бичиж гарын үсэг зуруулахад Алевтина Федоровна тэр өргөдлийг уншиж үзээд,

-Ийм бичиг цаас ерөөсөө байгаагүй гэж саная хэмээн урж хаясан. Тэгээд тэр тухай хожим хэзээ ч дурсаагүй. Харин нэг сарын дараа Нинад намд элсэх батлан даалт гаргаж өгсөн.

Нина Алевтина Федоровнад үнэн голоосоо итгэдэг билээ. Иргэний дайнд оролцсон, 1919 онд намд элссэн энэ шингэн шулуун үстэй, дугариг царайтай, тохмол шилтэй, намхан пагдгар авгай Нинагийн хувьд намч нинжин сэтгэлийн биелэл, даган дуурайх үлгэр болж яваа юм.

Хэдий тийм боловч Варягийн тухай тэр авгайд ярина гэдэг бол дүүгийнхээ хариуцлагыг, ярьсан зүйлсийнх нь хариуцлагыг түүнд тохно гэсэн хэрэг. Авгай тэр хоёрын тухай юм мэднэ гэсэн үг, гэтэл одоо цагт м э д н э гэдэг бас хариуцах ёстой гэсэн үг. Нина дуугүй байгаад байж болох л доо, үнэмшил муутай ч гэсэн арга барагдахад хэлэх шалтаг эрхбиш байна. Варя

жинхэнэ үзэл бодлоо өөрөөс нь нуудаг учраас мань хүн сайн мэдэхгүй байсан гэх буюу эсвэл дүү нь нэг л биш байсныг анзаарч илэн далангүй ярилцах гэж оролдсон боловч бүтээгүй гэхчилэн хэлж болох талтай. Нэг үгээр хэлэхэд, хэдийгээр хэргээс бултаж, хариуцлагаас зайлсхийхийг оролдох нь муухай боловч яаж ийгээд шалтаг зааж болохоор.

Харин Алевтина Федоровнад бол өөрийгөө зөвтгөх юм олдохгүй. Нина түүнд ярьчихлаа гэхэд Тэрээр хуучин шавь нарынх нь нэг тиймэрхүү юм ярьдгийг мэдэх болно гэсэн үг, тэгээд дуугүй өнгөрсөн байж таарахгүй. Тэгэхээр мөрөөр нь заавал ажиллах ёстой болно.

Нина баахан эргэлзэж, чухам хэрхэхээ шийдэж эс чадан нэг хэсэг болжээ. Тэгтэл нэг тохиолдол тус болов. Алевтина Федоровна аминчлан ярилцахаар мань хүнийг өөрөө дууддаг байгаа даа.

Алевтина Федоровнаг тухайн үедээ Гэгээрлийн Ардын Комиссарын газраас тэдний сургуулийг бэхжүүлэхээр ирүүлсэн билээ. Хүүхдийнх нь нийгмийн бүрэлдэхүүн муу, багш нар нь яггүй тэрсүүд үзэлтэй, хуучин гимназийн үзэл санаа нэвт шингэсэн сургууль байж.

Алевтина Федоровна тэр үзэл санааг бүрмөсөн үгүй хийж чаджээ. Залуу багш нартай болж. Нина ч тэдний дотор ирсэн хэрэг. Пионер, комсомолын байгууллага бий болж. Эцэг эхийн чөдөр тушаа болсон хуучин зөвлөлийг шинэ төлөв зөвлөлөөр сольж.

Энэ сургууль хувьсгалын өмнө, бас хувьсгалын дараа явцуу хүрээний хаалттай сургууль байсан бол одоо тийм байхаа больж, дүүргийн ердийн дугаартай, ердийн нэгэн хөдөлмөрийн дунд сургууль болжээ.

Үүний хамтад Алевтина Федоровна ч ердийн нэгэн хөдөлмөрийн дунд сургуулийн захирал болон хувирчээ. Тэрээр уул нь Гэгээрлийн Ардын Комиссарын газарт ч, түүнээс өмнө ч яггүй хариуцлагатай алба хашиж байсан билээ. Тэгээд дунд сургуульд түр томилолтоор очоод тэр чигээрээ мартагджээ. Шинэ ажилд томилоно хэмээн он жилээр хүсэн хүлээсэн боловч юу ч өгсөнгүй. Тийнхүү албан тушаал буурсан хэрэг болчих нь тэр.

Алевтина Федоровна анх шилжиж ирэхдээ цаанаа л нэг дорвилог донжтой байсан, тэр нь ч бүдгэрээд ирж. түүний дайчин байдал хэнд ч хэрэггүй, ямар ч шаардлагагүй, тэр ч атугай инээдэмтэй зүйл болж хувирсан. Шаардах нь өөчлөхөөр, хатуурхах нь уцаарлахаар солигдсон. Сурганы сонгомол боловсрол эзэмшсэн тэрбээр яваандаа хуучин багш нартай нэгсэн гар нийлсэн. Өөрөөр хэлбэл, шавьдаа үнэхээр юм сурахыг шаарддаг, дүнг нь өргөдөггүй, сурганы болон бусад элдэв туршилтыг үгүйсгэдэг багш нартай нэгсэх болжээ. Алевтина Федоровна наймдугаар ангийн сурагчид Гамлетийн нийгмийн гарлыг мэдэж байгаа хэрнээ таслал хаа тавьдгийг мэдэхгүй буй арчаагүй байдлыг мэдэнгүүт Переверзевийн номлолыг шүтэгч хэл утга зохиолын залуу багшийг сургуулиасаа хөөж, өгүүлбэр зүй, зөв бичлэгийн болон цэг таслалын дүрэм зэргийг хүүхдэд зааж сургадаг хуучин багшийг эргүүлж авсан.

Алевтина Федоровна Төв хороо, Ардын Комиссаруудын Зөвлөлийн нэг тогтоолын тухай найз нараасаа тухайн үедээ сонссон билээ. Тэр тогтоолд түүхийн хичээлийг заахдаа түүхэн зүтгэлтнүүд болон үйл явдлын он цагийн хэлхээсийг сурагчдын ой ухаанд шингээж байх ёстой атал одоогийн сургалт нь хийсвэр шинжтэй, сурагчдад хоосон тодорхойлолт хэлж өгч

байгаа тухай дурдсан байсан.

Одоо тэр тогтоол нийтлэгджээ. Санаанд оромгүй тогтоол. хүн төрөлхтний түүх бол ангийн тэмцлийн түүх, түүхэн зүтгэлтнүүд бол зөвхөн тэдгээр ангийн эрх ашгийг илэрхийлэгч гэх томъёонд багш нар нэгэнт дассан билээ. Гэтэл одоо түүх бол аугаа их хүмүүсийн бүтээл хэмээх үзлийг буцааж баримтлах ёстой болох нь уу?

Алевтина Федоровна энэ тогтоолыг үзээд гайхширч сүйд болсонгүй. Тэрээр намын дээд бодлогын төлөөлөгч болохоор энэ бодлого яаж ч урваж хөрвөж байсан үл гайхна. Төрийн удирдлагынхныг ойрхноос харж байсан төдийгүй тэдний оронд өөрөө ч байвал байх хүн гэж үздэг учраас тэднийг өөртэйгөө эн тэнцүүхэнд тооцож, дээд шатны байгууллагуудыг бишрэн хүндлэх нь үгүй. Хэзээнээс нааш Троцкийг хөндлөнгийн этгээд, троцкистуудыг жижиг хөрөнгөтний хэнгэрэгнүүд, Зиновьев, Каменев хоёрыг хий уймагчид гэж үзнэ. Харин Рыков, Томский, Бухарин зэрэг оросын үндсэн большевизмын төлөөлөгчдөд дотносог хандана. Гэтэл тэд нар нь удирдлагыг гартаа авч байх тамиргүй амьтад гэдгээ харууллаа. Тэрээр одоо Сталины талд зогсож байна. Сталины үнэ цэнийг мэддэг, түүний шинж чанарыг бахдан биширдэгтэй тэр биш, Сталин бол өнөөгийн нөхцөлд жолоо барьж чадах цорын ганц хүн мөн гэсэндээ тэр. Барих барихдаа барьсан шиг барина. Намаа ч мэднэ, хүнээ ч мэднэ, бэлэн амлагч биш, биет ажлын хүн.

Алевтина Федоровна өөрөө ч биет ажлын хүн, хүнийг түүний оруулж буй ашиг тусынх нь үүднээс л үнэлнэ. Нэг удаа түүхийн хичээл дээр “Декабристууд ий? Тэд нар чинь юу бүтээсэн юм бэ?” гэж асууж байсан ч явдал бий.

Ер нь түүхэнд бие хүний гүйцэтгэх үүргийг нотлоно гэдэг нь тухайлж авч үзвэл Сталины үүргийг өргөмжлөн магтана гэсэн үг гэдгийг Тэрээр ойлгож байлаа. Ер нь ч бие хүний ач холбогдол бага гэж үү? Ленин байгаагүй бол Октябрийн хувьсгал болох байсан уу? Сталиныг амьд сэрүүнд нь Ленинээс илүү магтаж байна. Гэтэл энэ хоёр бол хооронд нь жиших зүтгэлтнүүд биш. Лениний нэр төрийг бататгах хэрэг байгаагүй, юун төлөө Ленин билээ дээ, харин Сталин бол дөнгөж л Сталин юм чинь түүний нэр төрийг бататгахаас өөр арга байхгүй. Гэтэл Сталины нэр хүнд гэдэг бол намын нэр хүнд, намын боловсон хүчний нэр хүнд. Сталин намын гишүүдийн хүчинд л өдий зэрэгтэй яваа шүү дээ.

Түүхийн шинэ сурах бичгүүд хараахан бэлэн болоогүй байна. Хуучныг ашиглаж болохоо байсан. Үүнтэй холбогдуулж Алевтина Федоровна Нинаг урьсан байжээ. Бүх Холбоотын түүхийн багш нарын зуны дугуйлан зохион байгуулагдаж, тэр дугуйланд хожмоо хот, дүүргийн багш нарын дугуйланг өөрснөө удирдан явуулж чадах тэргүүний багш нарыг илгээж байгаа юмсанж. Алевтина Федоровна Нинагийн нэрийг дэвшүүлж байгаа нь түүнд сайн санаж явдгийн бас нэг нотолгоо.

-Баярлалаа, Алевтина Федоровна, би энэ үүргийг биелүүлэхийг хичээе.

-Чи чадалгүй яахав хэмээн Алевтина Федоровна Нинад урам нэмж, -Маргааш шийдвэр гарна, нөгөөдөр дүүргийн боловсролын хэлтэс дээр очиж томилолтоо аваарай. Юмаа сайн тогтоож, бичиж тэмдэглэж аваарай. Чи өөрөө дараа нь бусдад зааварчилгаа өгнө шүү.

-Би бүгдийг нь тогтоож авна аа.

Тэрээр Алевтина Федоровнагаас (ийм боловсон хүчнийг үнэлэхгүй байхдаа яадаг юм бэ!) болоод Гэгээрлийн Ардын Комиссарын газрын удирдлагад дургүй нь хүрдэг юм.

Харин энэ зуур ганцхан юм л толгойд нь эргэлдээд байв. Алевтина Федоровнад Варягийн тухай хэлэх үү, байх уу?

Алевтина түүнийг нэвтрэх мэт харж,

-Чи аль нэг юманд санаа зовоо юу? гэж асуув.

-Гойд юмгүй ээ хэмээн Нина түгдрэв.

-Чи яачихаав, ярь! гэж Алевтина Федоровна тушаалаа.

-Миний дүү, Варя, та санаж байна уу?

-Саналгүй яахав. Хөөрхөн охин. Тэр яачихаав?

-Сайхан амьдралд хууртан нэг бильярдчинтай суухчаан болсон юм, тэгснээ түүнээсээ салсан, тэгээд л урам хугарах, санаа сэтгэл алдрах гэхчилэн элдэв л юм болж байна.

Алевтина Федоровна Нинаг сонжин харав. Юмны учир бильярдчин, ресторан энэ тэр биш гэдгийг гадарлаж буй хэрэг.

Нина “Зөвлөлтийн эсрэг яриа” гэдэг үгийг хэлж зүрхлэлгүй дуугүй болов. Энэ тухай ярьж болохгүй гэдгээ гэнэтхэн ухаарлаа. Тэр үгийг Алевтина Федоровна их нухацтай авч үзнэ, заяа нь налиглахгүй. Тэгэхээр ямар ч санаанд оромгүй, ямар ч ноцтой үр дагавар гарч мэднэ.

-Тэгээд юу гэж? хэмээн Алевтина Федоровна хүнийрхүү ширүүн асуув.

-Юу гээч үгүй. Юунд санаа зовоо вэ гэж асуухаар тань л зүгээр ярьсан юм.

Тэгээд ийнхүү хэсэгхэн зуур сэтгэл алдарсандаа өршөөл эрэх мэт инээмсэглэв.

-Зөвлөлгөөн Ленинградад болох учиртай, гэхдээ Москвад, Улаан эрдэмтдийн дээд сургуулийн байранд ч болж магадгүй.

Нина, Ленинградад болвол зүгээрсэн, тэгвэл Москвагаас явж, хоёр сар хэртэй Варятай уулзахгүй юу шиг байх вэ, одоо цуг байхад тун яршигтай байгаа юм чинь гэж бодов.

Варя оройн ангид орсондоо тун додьгор байв. Одоо түүнийг ямар ч хуралд, хэн ч чирч оруулж чадахгүй, Тэрээр нүд нь орой дээрээ гарч “Сургуулиа яах билээ?” л гэчихнэ. түүнээс гадна нэмэгдэл сул өдрүүдтэй болно, жишээлбэл шалгалтад бэлтгэх хэд хоног. Нэмэрт нь оройн ангид улс төр, эдийн засгийн ухаан гэх мэтийн нийгмийн ухааны элдэв хичээл бараг ордоггүйг ч хэлэх үү, ажлынхаа нэрийг бариад сонирхолгүй хичээлийг таслаж болно. Харин мань хүн хамт олондоо түвэг удахгүйн тулд ажлаа таслана гэж байхгүй.

Тэгээд ч хамгийн гол нь хичээл нь тун хялбархан байлаа. Тэрээр дунд сургуульд сурлага сайтай байсан, тоо, физикт авьяастай болохоор хэдийгээр гэртээ хичээлээ огт давгддаггүй ч гэсэн, ер нь гэрийн даалгавар гэж бага, ер нь байхгүйтэй адил л даа, жирийн барилгачин, аравны дарга, бригадын дарга годлуу ангийнхан дотроо магнайдаж, бүлгийнхээ бахархах нэгэн болжээ. Оройн ес гэхэд суларч Софья Александровнагийн очих буюу кино үзэж амжина. Зоягаас дөлдөг болсон тул кинонд ганцаараа явна.

Нэг удаа Варя номын сангаас буцаж явахдаа Викатай тааралдав.

Вика зогтусан малилзтал инээмсэглэж, Варяг тэвэрч авч үнсэв. Тэгснээ тэр даруй цүнхнээсээ “Коти” хэмээх сүрчиг ханхлуулсан нусны алчуураа гаргаж Варягийн хацраас уруулын будагнахаа ормыг арчлаа. Тэрээр гоё ганган гэдэг хуучин янзаар. Хул шар пальтотой, мөн тийм өнгийн дугуй малгай духдуулжээ. Хөгжүүн хөхүүн ч гэж учиргүй, амьтан хүний анхаарал хараа тээглэх нь элбэг, хажуугаар өнгөрөх хүмүүс эргэн эргэн харцгаана.

-Варя, хонгор минь, чамтай тааралдсандаа ёстой баяртай байна.

Варя харин баярласан уу? Хэлэхэд хэцүү. Нарийн яривал хүний л хүн. Гэхдээ Сашагийн оролцсон нөгөө Шинэ жилийн баяр санаанд орж ирлээ. Бас анх удаа орж үзэхдээ Левочкагийн бүлэгтэй танилцсан нөгөө ресторан санаанд орж ирлээ. Тэгээд Варя хариу болгож инээмсэглэв.

-Чи хаачиж явна? гэж Вика асуув.

-Харьж явна.

-Манайхаар орох юм биш үү? гэж Вика санал болгов.

-Үгүй ээ, манайхан намайг хүлээж байгаа.

-Өө, тэгвэл би чамайг дөхүүлж өгье.

Вика Варятай зэрэгцэн алхах зуур түүнийг байн байн харж, хөгжилтэй инээмсэглэн явах нь ийнхүү уулзсандаа үнэхээр баяртай байгаа мэт. түүний ярианаас нөгөө хуучин танимхайрч явсан үеийнх лүгээ адил тэс өөр амьдралын үнэр, өөрийн бие даасан хуулиар замнадаг эрх зоргоороо амьдралын үнэр, хориотой юм, бас чадахгүй юм гэж байдаггүй азтан, золтонгуудын амьдралын үнэр дахиад ханхлаад явчихлаа. Энэ тийм биш, бүхнийг чаддаг,

хориотой бүхнийг болгодог хүмүүс гэж байхгүйг Варя мэднэ. Гэхдээ тэгж харагдах нь бий, тийм з э р э г л э э бий. Тийм амьдрал хуучин шигээ сэтгэл эс татавч нэгэн үе сэтгэл татаж, шохоорхон хөл алдаж явсныг сануулах ажээ.

-Костя та хоёрыг салсан юм шиг дуулсан? гэж Вика асуув.

Варя энэ сэдвээр ярихыг хүсээгүй тул,

-Тэгсэн гэж дурамжхан хариулав.

-Чиний хэрэгт оролцож байгааг уучлаарай, Варя. Та хоёрын гэрлэлт яаж дуусахыг мэдэж байсан учраас би бүр анхнаасаа ойлгох ч үгүй, сайшаах ч үгүй байсан юм. Чи түүний тухай надаас лавлаагүй, надтай ярилцаагүй нь даанч тоогүй. Уул нь, Варенька минь, би чамд хэзээний сайн, чамайг сайн сайхан яваасай л гэж дандаа хүсдэг, одоо ч тэгж л хүсч байгаа шүү дээ. Гэтэл чи ямар ч шалтгаангүй гэнэтхэн надтай үерхэхээ больчихсон. Би чамайг ямар нэг юмаар гомдоочихсон юм уу?

-Аяс нь л тэгж таарахгүй юу гэж Варя тогтуухан хариулав. Вика өрөвдөнгүй толгой дохиж,

-Би ойлгож байна, бид нар цөмөөрөө л дур шохоорхлынхоо боолууд юм чинь. Намайг хэнтэй суусныг чи бодвол дуулсан байлгүй? гэв.

-Дуулсан.

-Ёстой гүндүүгүй сайхан хүн, бусад юмыг ярихыг больё гэхэд авьяасыг нь яана. Надад хайртай. Гэхдээ өглөө эрт гараад их оройтож ирдэг, заримдаа урландаа хонодог болохоор надад бараг үзэгдэхгүй л дээ. Гэвч яая гэхэв? Аливаа суу билигтний адил мань хүн ажилдаа амиа тавина... Би тэвчих ёстой. Гэхдээ уйтгартайхан л байх юм.

-Ажилд орохгүй юу гэж Варя хэлэв.

-Өглөө зургаад босох хэрэг үү?.. Хотын энгээр трамвайн сэгс- чүүлнэ... А р г э р, аж ахуй тэр чигээрээ над дээр тохоостой, нөхрөө халамжлах, эцгийг бас Вадимыг харж хандах ажил бүгд минийх шүү дээ... Манай нөхөр яаж ажилладгийг чамд хэлсэн. Эцэгт ч дээрдэх юм байхгүй, мань хүн сургууль, анагаахын хүрээлэн, Кремлийн эмнэлэг гээд толгой өөд татах завгүй, бас шөнийн дуудлага ирнэ, түүнийг хооллож ундлах хэрэгтэй, бэлтгэж явуулах хэрэгтэй. Би ч чухамдаа гэрийн эзэгтэй. Вадим нэртэй шүүмжлэгч, мундаг сонинчин болсон. Гэтэл хэвлэлийн газрын амьдрал чинь хуй салхи л гэсэн үг, заримдаа тэднийг редакцид нь өглөө хүртэл барьчихна. Ийм гурван хүнд арчилгаа халамж шаардлагатай, тэгээд л би тэдэнд үйлчилж байгаа юм.

Тэрээр Варя руу хяламхийснээ,

-Манайхны харчуул намайг ажилд орно гэхийг сонсох ч дургүй шүү гэж нэмж хэлэв.

Гэрийн үйлчлэгч Фенягаа, өглөө хөнжилдөө байхад нь кофе авчирч өгдөг Фенягаа дурсахаа мартчихсанаас биш уул нь ч бүх юмаа хэллээ гэж бодоод Варя дотроо эгдүүцэв.

Тэгээд гэнэн царайлан,

-Феня танайд үйлчлэгч хийхээ больчихсон юм гэж үү? гэж асуув.

-Хийж байгаа. Гэхдээ Феня бол Феня шүү дээ. Манайд чинь хүн хар ирнэ, зүгээр ч үгүй жир бус хүмүүс гэдгийг чи ойлгож байгаа. Тэднийг хүлээж авсан шиг авах хэрэгтэй, тэр ажлыг ганцхан би л чадна. Ер нь юу ярихав. Би гомдол мэдүүлж байгаа биш, зүгээр л амьдралынхаа тухай ярьж байна шүү дээ. Хаашаа ч явдаггүй, хаана ч очдоггүй. Бас над дээр ирдэг хүн ч алга. Үгүйдээн чи яаж ийгээд манайхаар орох л доо, Варя.

-Хэзээ очих вэ дээ? Өдөр нь ажиллаад, оройн цагаа сургууль дээр өнгөрөөх юм чинь.

-Өө, тийм үү? Сайн байна! Ямар сургууль дээр?

-Барилгын.

-Юун сайн юм бэ! Уран барилгачид, барилгын инженер гээд энэ шугамаар надад маш олон танил бий, тэдний тусламж хэрэгтэй юм биш биз?

-Үгүй ээ, ямар ч тусламж хэрэггүй гэж Варя хариулав.

-Тэгвэл ч яахав, түүнээс биш баараггүй шүү дээ. Би зөвхөн өөрийнхөө нөхрийг хэлж байгаа юм биш, танилуудаа хэлж байгаа юм... Дэлхийд нэр цуутай хүмүүс... Тэд ганц үг дуугарсан байхад л чиний бүх хэрэг бүтнэ.

-Юу ч хэрэггүй ээ гээд Варя хөмсөг зангидав.

-Хэрэггүй бол хэрэггүй л биз.

Вика зогтусав.

-Миний утсыг гээчихээгүй биз дээ?

-Үгүй шүү.

-За тэгвэл сайн байна. Утасдаарай, ирээрэй, энэ тэрийг бурж, жаахан сууцгаая...

Хоёрдугаар сарын дундаас шуудан тогтмол ирж эхлэлээ. Саша арванхоёр, нэгдүгээр сарын сонингоо авлаа. Гуравдугаар сард хоёрдугаар сарын сонин ирлээ.

Николаев Кировыг алснаас хойш хилийн чанадаас илгээсэн, тэгээд Москва, Ленинград, Киев, Минск хотуудад цаазлуулсан алан хядагчдын зөндөөн урт нэрсийн жагсаалт сонинд бараг өдөр бүр нийтлэгдэх болжээ.

Чухамхүү тэд нар л Кировыг алжээ гэсэн сэтгэгдэл газар авлаа. Гэтэл Лениградын комсомолын удирдагчид асан зиновьевчууд өс санаж Кировын аллагыг зохион байгуулсан, тэд нар бас Сталин болон нам, засгийн бусад удирдагчдыг алах санаатай байсан гэж 1934 оны арванхоёрдугаар сарын эцсээр олон сонин мэдээлжээ.

Бүх яллагдагсадыг чухам тэр үеэр цаазлан хороожээ.

Гэтэл 1935 оны нэгдүгээр сард урьд нь намын томоохон зүтгэлтэн явсан бусад нөхдийнхөө хамт нөгөө Зиновьев, Каменев, Евдокимов, Бакаев энэ тэр гээд нийтдээ арван есөн хүн ялын ширээнд оччихсон байв. Тэд Кировыг алахад шууд оролцсон нь шүүх хуралдаанаар нотлогдоогүй ч гэсэн Зиновьевт ямар ч атугай арван жилийн, бусдад нь найм, зургаа, таван жилийн гэхчилэн ял заажээ.

Шүүн таслах ажиллагаа өмгөөлөгч ч байхгүй, цахилгаан мэт түргэн болж өнгөрсөн ч зиновьевчуудыг аллагад холбогдуулсан таамаг нь нээрэн үнэмшмээр байжээ. Өөр хэн энэ хэргийг хийхсэн билээ? Олон сонинд гарснаар Николаев урьд өмнө нь өөрөө болон бүх нөхөд нь зиновьевчууд байсан гэж байгаа, тэгэхээр Зиновьев, Каменев хоёр тэднийхээ төлөө ёс суртахууны хариуцлага хүлээх ёстой нь мэдээж. Тэд нарыг тийм хатуу ялд унагах нь эргэлзээтэй боловч ямар ч атугай Кировыг алчихаж! Алчихаж шүү дээ! Зиновьев, Каменев хоёр биш ч гэсэн тэдний санаа нэгтэнгүүд нь алчихаж. Алчихаж шүү дээ!

Зиновьев, Каменев хоёр бүр арван долоон онд Түр засгийн газарт бослогын тухай шийдвэрийг гаргаж өгсөн. Троцкийг намын заналт дайсан гэж зарлагдсаны хойтон жил, хорин зургаан онд түүнтэй нэгдэцгээсэн. Эдүгээ Гитлер хуурай замын хагас сая цэрэгтэй арми, хүчирхэг нисэх хүчин байгуулж, манай руу шууд дайтахаар заналхийлж, фашист аюул нүүрлэхээд байхад халирхай байж болох уу. Нам аливаа цохилтод хариу цохилт өгнө. Чингэхэд хэдийгээр, харамсалтай нь, алдаа завхрал гардаг, гэм буруугүй хүмүүсийн амь насыг бүрэлгэдэг ч гэсэн.

Тийм ч учраас Саша эх орныхоо ололт амжилт, ард түмний урам зориг, итгэл үнэмшлийг ухаан суусан цагаасаа амьдрал ахуйдаа эрхэмлэн дээдлэж ирсэн, улс орны амин судас ч энэ бүхнээр л лугшиж ирсэн болохоор сониноо анхааралтай унших зуур тэнд буй хийрхэл, зүхэл, хорсолын цаанаас нөгөө л өөртөө эрхэм зүйлсийг олж мэдрэхийг хичээх бүлгээ. Ард түмний тэрхүү итгэл л өөрийнх нь итгэлийг тэжээж буй билээ.

Саша заримдаа Лидия Григорьевна Звягуро дээр очно.

Тэр авгай Ларискагийн дунд суудаг хэвээр, маш их ажилтай, ялангуяа Кежмийнхэнд зориулж машинаар, гараар өчнөөн юм оёно. Хүүхнүүд одоо Ларискагийн дунд ирж, энэ хавьдаа нэрд гарсан учирлагч Звягуро авгайтай юуг яаж оёхыг шүүн хэлэлцдэг бөгөөд Лариска ч түүнийг хүндлэн дуулгавартай хандаж, тэр яриа хөө-рөөнд нь оролцох болсноор энэ гацаандаа төдийгүй бүр Кежмад ямар хэрэг явдал гарсныг нэгд нэгэнгүй мэддэг, тэр чанараараа тосгоны авгайчуул давамгайлсан амьдралд хэрдээ мундаг үүрэг гүйцэтгэх болжээ. Гэхдээ Лидия Григорьевна өөрийгөө хүнээр хүндлүүлж чаддаг, эзэрхий хүн байсан болохоор Лариса түүнээс зүгээр л эмээдэг байсан байж ч мэднэ.

Звягурогийн хөвүүн Тарасик гэж дуу цөөнтэй хүүхэд голдуу вандан дээр сууж байх бөгөөд хаа нэгтээ модны өөдөс оролдож байвал тоглож байгаа нь тэр. Лидия Григорьевна орсой шүдтэй, царай дортой, хуучны дүртэй авгай бөгөөд бас амаа үдүүлчихсэн мэт барагтай бол дуугарахгүй.

Саша авгайд сонин авчирч уншуулдаг, хэд хоногийн дараа цаадах нь буцааж өгдөг, гэхдээ Всеволод Сергеевич шиг элдвийг цуурч бурахгүй, ер нь уншсанаа тойруулж ярих нь тун ховор. Гагцхүү Зиновьев, Каменевийг шүүх ажиллагааны талаар,

-Жүжиг эхлэж байна гэх төдий өгүүлсэн.

-Гэхдээ Кировыг алчихсан шүү дээ гэж Саша зөрөхөд,

-Сонинд юу дуртайгаа бичиж болно хэмээн Звягуро шаралхан үгийг нь тасдаад, -Зиновьев, Каменев хоёр хэзээ ч тийм хэрэг хийхгүй, ингэхийн хэрэгцээ ч тэдэнд байхгүй. Кировыг алах нь ганцхан хүнд л ашигтай.

Авгай ямар хүний тухай ярьж буйг Саша ойлгож байв.

-Гэтэл нам, ард түмэн...

-Манайд нам байхгүй гэж Звягуро үгийг нь тасдав. -түүний бодлогыг дуулгавартай хэрэгжүүлж байгаа боловсон хүчин л байна. Тэр хүн намыг үзэн яддаг учраас түүнийг устгаж байна.

Саша сонины хуудаснуудыг гүйлгэн харлаа.

-Сталин ард түмний тухай ингэж хэлж байна: “Цэцэрлэгч хүн шохоорхсон жимсний модоо арчлан тордож үржүүлэх лүгээ адил хүмүүсийг анхаарч халамжлан бойжуулах хэрэгтэй”.

-“Цэцэрлэгч”, “мод” гэнэ шүү. Кавказ маягийн манж үг хэмээн Звягуро дахин дундуур нь оров. -Хөдөөд хичнээн сая тийм “модыг” тэр чинь огтолсон билээ, хичнээн сая хүн өлсгөлөнгөөр үхсэн билээ?

Саша мөчөөгөө өгсөнгүй,

-Тэгж яривал тосгоны тухай тэр чинь ингэж хэлсэн байна: “Хамтралчин айлд өөрийн гэх хувийн аж ахуй байх ёстой, бага шиг, гэхдээ л хувийн аж ахуй... Айлд ам бүл, хүүхэд гэж

байна, хувийн хэрэгцээ, хувийн дур сонирхол гэж байна, үүнийг тооцохгүй байж болохгүй”.

-“Хувийн дур сонирхол”, “тооцохгүй байж болохгүй” хэмээн Лидия Григорьевна тохуурхан давтав. -Та тэгээд ийм солиотой юмыг үнэмшиж байгаа юм уу? Тариачдад ямар нэгэн амин зуулга хэрэгтэй, байхгүй бол бүгдээрээ мажийчихна гэдгийг тэр чинь, мэдээж, ойлгож байгаа, мажийчихвал мань хүн хэнийгээ жолоодохсон билээ? Та т ү ү -н и й г мэдэхгүй, би бол мэднэ. Яг одоо таныг харж байгаа шиг олон жил нүүр учирч явлаа. Хүмүүс, тэдний амь нас мань хүний хувьд юу ч биш, тэр бол эрүүгийн хэрэгтнээс дор, хэрэгтэй бол хэнийг ч хамаагүй алчихна. Тэр бол жүжигчин, ямар ч дүрд тоглож чадна. мань хүн одоо хүмүүсийн тухай ярьж, ард түмэнд зулгуйдаж байна. Аливаа харгислагч тэгдэг юм. Ухаантай харгислагч аман дээрээ ард түмэнд байнга зулгуйдна, ачир дээрээ бол ард түмнээ устгаж байдаг юм. Тиймэрхүү санаа таны толгойд орж ирж байгаагүй юү?

Нээрэн, тийм санаа Сашагийн толгойд орж ирж байсан, орж ирэхгүй байхын аргагүй. Гэхдээ мань хүн Сталины хэлсэн үгнүүдийг шимтэн уншихдаа, түүнийг үзэн ядах үзэл нэвчсэн Лидия Григорьевнагийн төсөөллөөр бус чухам ямар хүн бэ гэдгийг өөрөө, өөрийнхөөрөө ойлгож авахыг хичээж байжээ.

-Та дуугүй байх шив? хэмээн авгай Сашаг дооглонгүй эрэгцүүлж харснаа өмднийх нь түрийний эргүүлгэн дээр хараа нь тогтов.

-Та чинь яахаараа ийм ноорхой өмдтэй явдаг байна аа?

Саша улсхийлээ. Цорын ганц өмд нь энэ, Маркийн бэлэглэсэн хос костюмыг эс тооцвол Москвад ч илүү өмд байхгүй.

-Цацаг үүсэхээр нь би хайчаар таначихдаг юм.

-Яасан хурц ухаан бэ... Тэр хөшигний ард суузгаж бай, би наад өмдийг чинь янзлаадахъя.

Дууных нь өнгөнд нөгөө л зөрөхийн аргагүй эрсхэн аяс илт. Саша хөшигний цаад руу сонингоо авч ороод үргэлжлүүлэн уншлаа.

“Ажилтан нарт хүнд суртлын хүйтэн цэвдэг сэтгэлээр эсвэл бүр жигшүүртэй муухайгаар хандах явдал бидэнд замаас аван тохиол-дож байна... Хүмүүсийг шатрын хүүн чинээ ч тоохгүй шидлэх үзэгдэл ховор биш... бид юуны өмнө хүмүүсийг, боловсон хүчнийг, манай нийтийн үйл хэрэгт тус хүргэх чадвартай ажилтан нэг бүрийг үнэлж сурах ёстой. Ертөнцөд байдаг бүх үнэт капиталаас хамгийн үнэтэй, хамгийн шийдвэрлэгч капитал бол хүмүүс, боловсон хүчин гэдгийг одоо эрхбиш ойлгох хэрэгтэй”.

Энэ бүхэн бол Сашагийн өөрийнх нь тухай, Саша шиг хүмүүсийн тухай л зүйл байна шүү дээ. Лидия Григорьевнад уншиж өгөх ёстой байсан юм чухам л энэ байж.

Гэвч хөшигний ард өмдгүй сууж байж хүнтэй ярилцах нь мунхаг хэрэг.

Лидия Григорьевна тэгсхийгээд сэлбэсэн өмдийг нь өгч,

-Хувцаслаарай гэв.

Саша өмдөө өмсөөд хөшигний араас гарлаа.

Тарасик нөгөө л байсан газраа модоор тоглоод сууж байв.

-Тарасик, гарч жаахан зугаалъя гэж Саша хэлэв.

Тарасик Лидия Григорьевна руу асуусан царайтай харлаа.

-Тэг тэг, өдөржин гэртээ суух юм, явж зугаал! хэмээн Лидия Григорьевна зөвшөөрөв.

Авгай Тарасикийг хувцаслаж өгөөд, хэдийгээр хүйтний эрч харьсан ч алчуураар хүзүүг нь ороож, хоёр тийш нь зөрүүлэн боовоос мань хоёр гадагш гарч Ангар руу явлаа.

Зөрүүлж боосон алчуурандаа түүртсэн, дуу шуугүй, хэрсүү бяцхан бандь Сашатай зэрэгцэн алхана.

-Чи хэдтэй вэ? гэж Саша асуув.

-Мэдэхгүй... Үгүй ээ, долоотой.

-Тэгвэл мэдэж л байна шүү дээ. Уншиж чадах уу?

-Үгүй.

-Үсэг мэдэх үү?

-Мэднэ.

-Шүлэг?

-Үгүй.

-Тэгвэл ээж нь чамд шүлэг уншиж өгдөг үү?

-Өгдөг.

-Ямар шүлэг?

-Санахгүй байна.

-Би чамд уншиж өгөх үү?

-Тэг.

Тэр хоёр Ангарын эрэг дээр зогсож байлаа. Ээвэрлэх янзтай. Тарасик халууцав бололтой толгойгоо шилгээнэ.

Саша алчуурыг нь суллаж өгөв.

-Дээрдэв үү?

-А-хаан.

Тарасик холбоотой хоёр бээлийгээ мултлахад Саша түүний гарыг атгав.

-Даарахгүй биз?

-Хүүгийн турыгүй бяцхан хэрнээ бүлээхэн гар түүнийг цоргих шиг болж, Тэрээр явган суугаад алгыг нь алгандаа хавсран барив.

-Дулаахан байна уу?

-Дулаахан байна.

Хөвүүн түүн рүү хэрсүү харцаар харлаа. Тарасик хэзээ ч инээж үзээгүй байх гэж Сашад бодогджээ.

-За тэгээд шүлэг уншуулмаар байна уу?

-Уншуулмаар байна.

-Бээлийгээ хий.

Тарасик бээлийгээ өмслөө.

Саша өндийв...

Эргэн тойронд цасанд хучигдсан цөл цайрч, гагцхүү голын нөгөө эрэгт нэг захаас нь нар гийгүүлсэн ой харлан байна.

Тэгсхийгээд нар үүлний цаагуур орж бүүдийгээд явчихав.

-Энэ үүлс чамд ямар нэг юмыг санагдуулж байна уу?

Тарасик дал мөрөө хавчин,

-Үгүй гэв.

-Тээр тэр усан онгоц байна, харж байна уу? Шургааг нь харахгүй юу, мөстчихсөн юм шиг. Далбаанууд байна. Харж байна уу?

-Харж байна гэж Тарасик итгэл муутайхан өгүүлэв.

Лермонтовын “Агаарын хөлөг” Сашагийн санаанд гэнэтхэн орж, түүнийгээ Тарасикт уншиж өгөв:

Од мичид л огторгуйд анивчин байнам.

Омголон далайн хөхөлбөр мандлаар

Ороо салхины эрчлэх үзүүрээр

Орь ганц хөлөг хурдлан довтолгоном...

Энгүй тэр л далайд нэгэн арал байнам

Эл хуль дүнсгэр боржин арал ажам.

Энэ өнчин арал дээр нэгэн булш байнам

Эзэн хаантныг тэнд нутаглуулсан гэнэм...

Гунигт үхлийн цаг эгэн тохиох агшинд

Хуучин он өндөрлөх шөнө дөлийн мөчид

Агаарын хөлөг чимээгүйхэн ирж

Арлын цавчим эрэгт тулан зогсвой.

Тэгэхүйд хаантан гэнэт амилан сэхэж

Тээрт авснаасаа залран гарч иржээ.

Тэргүүндээ гурвалжин бүрх духдуулж

Тэлээ энгэрт аяны саарал нөмрөг агсчээ.

Хүчирхэг мутраараа элгээ тэвэрч

Хүмүүн тэргүүнээ гудайн алхалсаар

Хөлгийн жолоонд эзэн морилмогц

Хормыг товчлон алсын замд гарлаа.

Гоц алдар суу, хаан ширээгээ үлдээсэн

Голомт сахих хүү, бас торгон цэргээ орхисон

Элгэн халуун Франц нутгийнхаа зүг

Эзэн хаан яаран довтолгож явна...

Эзэнтэнбээр том том алхалсаар

Эрэг дээр зоримог шулуухан гарлаа.

Журмын нөхдөө хоолой мэдэн дуудлаа

Жанжин маршалуудаа үгүүлэн хашгирлаа...

Даан ч эзнээ гэх маршалтан алга гэнэ:

Даамай зарим нь дайн тулаанд эрсдэж,

Дагуул бусад нь түүнээс урван тэрсэлж

Дайчин зэр зэвсэгнээсээ нэгэнт няцжээ...

Шийдсэн хэргийн горь тасарсан

Эзэн хаан тэргүүнээ гудайлгасаар

Шидэт хөлөгтөө эгэн ирж

Ирсэн мөрөөрөө довтолгон буцвай.

Хөвүүн шүлгийг хүчлэн байж сонсчээ.

-За ямар вэ, гоё байна уу? гэж Саша асуув.

-Тийм байна, би харимаар байна гэж Тарасик хариулав.

Тэр хоёр буцаж ирлээ. Саша тэр даруй явах гэтэл Лидия Григорьевна,

-Сониноо мартчих нь хэмээн яриа өдөж саатуулав.

Тэгээд тохуурхан,

-Наана чинь танай Сталины зураг бүх хэлбэрээрээ байна. Тэр ч байтугай мань хүн чинь Өвлийн ордыг эзлэх дайралтад пролетарийн хороог удирдан орсон болж байна шүү гэж нэмж хэлэв.

Үнэхээр сонины дугаар болгонд нөхөр Сталины наад зах нь нэг, аягүй бол хоёр, тэр бүү хэл гурван хөрөг байх ажээ: Сталин ганцаараа, Сталин, Ленин хоёр, Сталин, Ворошилов хоёр, Сталин, Молотов хоёр, Сталин, Каганович хоёр, Сталин, Жданов хоёр, Сталин хамтралчдын дунд, Сталин цэргийнхний дунд, Сталин ажилчдын дунд, Сталины зурмал хөрөг, Сталины баримал дүрс гэх мэт.

Царицыны хамгаалалт, Ростовын чөлөөлөлт, Пермь, Дорнод фронт, Деникинийг бутниргэсэн, Улаан Армийн ой, Нэгдүгээр Морьт Армийн 15 жил, Польшийн фронт гэхчилэн иргэний дайнд байгуулсан ялалтуудын тухай нийтлэсэн том том өгүүлэл цөмөөрөө Сталинаар дүүрчээ.

Түүхч И.И.Минцийн хэлснээр бол 1917 оны аравдугаар сард “Сталин Лениний хүсэл зоригийг биелүүлэн большевикч хороодыг хөрөнгөтний засгийн газрын эсрэг босгожээ”. За тэр, Лидия Григорьевнагийн тохуурхсан зүйл яг энэ. Энэ ч ёстой шал худлаа шүү дээ! Бүх гавьяа Сталиных, Сталин хаа л бол хаа ялалт байгуулж байж. Үйлдвэр, завод, хамтрал болгоноос, Эльбрусын оргилоос, Казбекийн оройгоос Сталинд дэвшүүлсэн баяр талархал. Аливаа хэлсэн үг, аливаа өгүүлэл түүний нэрээр эхлэж, түүний нэрээр дуусна.

Сталиныг, түүний ном зохиол, хэлсэн үг, өгүүллийг үгээ олж ядан магтахад Саша бүр дээд сургуульд байхын эгдүү нь хүрдэг билээ. Тэр бүтээлүүд нэг л шалихгүй, эгэл санагддаг асан. Тоо томшгүй олон давгалт, “нэгдүгээрт”, “хоёрдугаарт”, “гуравдугаарт” хэмээсэн бэлэн зэлэн тайлбар, чөдөр тушаа болсон загварчлал, түүний ямар ч санаа, ямар ч үгэнд өчүүхэн төдий эргэлзэхийг хорьсон хориг цааз-энэ бүхэн үнэхээр яршигтай.

Гэтэл бусад хүн үүнд яршиглах нь битгий хэл харин ч болвоос шагшин баясдаг шүү дээ. Үнэхээр бүгдээрэнгийх нь буруу, харин мань хүн, бас түүн шиг хүмүүсийн зөв гэж үү?..

Тэр үед Сталин ард түмэнтэй ярьж байсан, тийм учраас ард түмэн түүнийг ойлгож, түүнд итгэж, түүнийг дагахуйцаар ярих ёстой гэдгийг Саша ойлгохгүй байсан байх. Энэ ард түмэн зуу зуун жилийн хоцрогдол, боолчлолыг амссан, түүнтэй ярьж чаддаг байх хэрэгтэй, түүний түвшинг дээшлүүлэх хэрэгтэй, гэхдээ энэхүү түвшинг нь харгалзахгүй байхын аргагүй. Тэгэхээр мань Саша ч өөрөө ард түмэн. Тэрээр юун дотор өсч өндийсөн билээ, тэргүйгээр, тухайлбал, улс орон, намдаа итгэх итгэлгүйгээр аж төрж чадахгүй. Тэгэхээр мань хүн намтайгаа, улс оронтойгоо цуг байх ёстой. Сталин эдүгээ нам, улсын эрхэм цогц учраас Саша түүнд хувиараа яаж ханддаг байх нь хамаагүй. Хувийн гоморхлоо огоорч чаддаг байх хэрэгтэй.

Чухам энэ учраас Сталинд захиа бичих санаа Сашагийн толгойд улам бүр хоргодох болжээ.

Эдүгээ бүгд л Сталинд захиа бичдэг, цаа-дах нь тэр бүх захидлын мянганы нэг хувийг ч унших боломжгүй, өөрийнх нь захиаг ч уншихгүй, тэр битгий хэл захиа нь түүнд хүрэх ч үгүй гэдгийг мань хүн мэднэ.

Хэдий тийм боловч Сталинд захиа бичсэнээр мань хүн өөрт ногдсон үүргээ биелүүлэх болно. Тэрээр энэхүү үүргийнхээ учир утгыг томъёолж чадахгүй ч гэсэн өөрт нь юу ч тохиолдсон, амьдрал нь яаж ч эргэсэн “Би Сталинд захидал бичиж байсан” гэж өөрөө өөртөө хэлж чадах юм. Тэгсний хэрэг гарсан уу? Гараагүй. Тэглээ ч гэсэн түүнд хандсан, яагаад гэвэл түүний нэрээр намдаа хандсан хэрэг.

Хоёр жилийн өмнө сургууль дээр нь мань хүний гунигт хэрэг мандаж байх үед Саша өөрөө өөрийгөө хамгаалж чадна гэж найдаж байсан болохоор Сталинд хандах, түүний цагаас хумслах эрхгүй гэж үзэж байсан. Одоо мань хүн өөрийгөө хамгаалж чадахгүй болсон, түүнд зөвхөн Сталин л туслаж чадна, эс тэгвээс ялын шинэ хугацаа авна, аягүй бол хориход орно, тэгээд л амьдрал дуусах нь тэр. Саша Сталины өөрийнх нь яриад байгаа нөгөө “жижигхэн хүн” чухамхүү мөний учраас, түүнээс гадна Тэрээр чин шударга хөдөлмөрлөж, ногдсон ажил үүргээ үнэнчээр хийж биелүүлэх учраас Сталинд хандана.

Энэ Сибирь хэмээх газрын мухарт, энэ олон ганцаардлын шаналгаат өдөр, уртын урт харанхуй үдэш, нойр хулжсан барагдаж дуусдаггүй шөнийг дамнасан эцэс төгсгөлгүй бодлоосоо залхаж Саша гэнэ гэнэ зөгнөлд авган элдвийг төсөөлнө. Алферов өөрийг нь авахуулахаар тэрэг явуулж байх, тэр хөсгөөр нь Кежма орж байх, Алферов түүнд Сталины нарийн бичгийн дарга нарын газраас “Панкратовыг Москвад яаралтай ирүүл” гэсэн цахилгаан ирснийг мэдэгдэж байх. Красноярскт очтол галт тэрэгний тасалбар бэлэн байж байх, тэндээс гэр рүүгээ залгаж ээждээ тэд дүгээр галт тэргээр очно, угтаарай гэж мэдэгдэж байх. Ээж нь Варятай хамт буудлын тавцан дээр тосч байх. Тэр гурав трамвайны зогсоол руу очиж байх. Тэгээд дөрөвдүгээр трамвайгаар гэр рүүгээ явж байх.

Саша захидлынхаа үг болгоныг цэгнэж, тун удаан эрэгцүүлэн нягталжээ... “хүндэт нөхөр Сталин! Танд зүрхлэн хандаж буйг минь өршөөгөөрэй. Би Улс төрийн нэгдсэн газрын дэргэдэх Онцгой Зөвлөлгөөний 1934 оны тавдугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор 58 дугаар зүйлийн 10-ын дагуу урьдчилан хоригдсон хугацааг оролцуулан гурван жилээр Сибирыг цөлөгдөж шийтгүүлсэн юм. Хугацааныхаа талаас илүүг нь би эдэлчихлээ. Гэвч би юуны учир шийтгүүлсэнээ мэдэхгүй. Би ямар ч гэм буруугүй. Би зөвлөлтийн дунд сургуульд, зөвлөлтийн дээд сургуульд суралцаж байсан, пионер, комсомолын гишүүн байсан, үйлдвэрт ажиллаж байсан, улс орондоо хэрэгтэй хүн байхыг хүсдэг, гэтэл гар хумхин суухаас өөр аргагүй байна. Ингэж амьдрах арга алга. Миний хэргийг дахин хянаж үзэхийг Танаас хүсье. Гүнээ хүндэтгэн ёсолсон. А.Панкратов”

Тэрээр захидал бичсэн боловч дотроо тээнэгэлзсэн учраас түүнээ явуулсангүй.

Өөрөө шударга байж чадаж байна уу? Гоёчилж хуурсан болохгүй биз? Өөрөө юу гэж ч эрэгцүүлэн бодож байсан, ямар ч учир шалтаг заалаа гэсэн сэтгэлдээ бол Сталинд хандах харьцаагаа өөрчлөөгүй шүү дээ. Харин ч болвоос элдэв юм үзэж, туулсны эцэст Сталинд улам бүр эргэлздэг болсон. Гэтэл одоо түүнд хандаж байна. Тэрээр ажил хийхийг хүсч байна, улс орон, намдаа зүтгэхийг хүсч байна гэж өөртөө үнэмшүүлж байгаа, гэтэл зүгээр л

өөрийгөө, хувийнхаа амьдралыг аврах, хувь заяагаа өөрчлөх гэж эрмэлзэж байгаа юм биш биз?

Тэгээд ч ийм захиа бичих нь гэнэн хэрэг бус уу? Хүрэх үү, үгүй юү? Унших болов уу, үгүй болов уу? түүний хэргийг дахин хянаж үзэх үү, үгүй юү? Мэдээж, хүрэх ч үгүй, унших ч үгүй, хэргийг нь дахин хянан үзэх ч үгүй. Өөрөө эхлэхийн хэрэг юу байна, До яаманд захидлаа уншуулахын хэрэг юу байна? Захидал чухамхүү тийшээ л очно шүү дээ.

Үгүй тэглээ ч гэсэн, тэглээ ч гэсэн...

Сталин 1935 оны тавдугаар сарын 14-нд Москвагийн метрог ашиглалтад оруулахад зориулсан баярын хуралд оролцохоор Холбооны ордны Баганат танхимд хүрэлцэн ирэв.

Тэрээр метрог барьж байгуулсан танхимд суугаа залуу хүмүүсийг хараад, тэдний зөвхөн ТҮҮН рүү хандсан, зөвхөн түүний үгийг хүлээсэн баясгалант хөгжүүн царайг хараад, залуучууд түүнийг дэмжиж байна, түүний эрин үед өсч бойжсон залуучууд бол түүний залуучууд, тэдэнд, энэ л ард түмний хүүхдүүдэд мань хүн л боловсрол олгосон, улс орныхоо аугаа их өөрчлөн байгуулалтад оролцох, өөрийн гэсэн хөдөлмөрийн гавьяагаа байгуулах боломж олгосон хэмээн бодолхийлэв. Эдний энэ хамгийн хиргүй бадрангуй нас үүрд түүнтэй холбогдон сэтгэл зүрхэнд нь хоногшин үлдэнэ, эдний залуу нас түүний нэрээр гэрэлтэн гийнэ, эд нар түүнд насанд туршдаа үнэнч явах болно. Эдний эрх мэдэлд хүрэх замыг өөрөө нээж өгөх ёстой, тэгвээс эд нар дэвшиж дээшилснийгээ түүний ач, зөвхөн түүний ач гэж сүсэглэх болно.

түүний бодлыг Булганин таслачихлаа:

-Нөхөр Сталин үг хэлнэ.

Сталин индэр рүү очлоо.

Танхим тэр чигээрээ бослоо...

Эцэс төгсгөлгүй хурайлан хашгиралдлаа...

Сталин тайвшрахыг уриалан гараа өргөсөн боловч танхимын шуугиан намдсангүй, бүгдээрээ аврага том хэнгэрэг дэлдэх мэт нэгэн хэмээр алгаа ташиж, тийнхүү дэлдэх бүрийд “Сталин!”, “Сталин!” гэсэн ганцхан үг тэнгэрийн дуу мэт начигнан цууриатна.

Сталин алга нижигнүүлэхэд дөжирсөн хүн. Гэхдээ өнөөдрийнх бол онцгой алга ташилт. түүнд түшмэд, комсомолын хүнд сурталтнууд баяр хүргэж байгаа бус харин тус орны ууган метрог бүтээсэн бетончид, малтагчид, гагнуурчид, слесарь гээд жирийн ажилчид баяр хүргэж байна. Энэ бол ард түмэн, ард түмний сор, ард түмний ирээдүй.

Алга ташилтын нүргээнд танхим доргиж сандал дээрээ харайж гарсан хөвүүд, охид “Нөхөр Сталин мандтугай!”, “Аугаа их жолоодогч нөхөр Сталинд-комсомолын ура!” хэмээн хашгирцгаана.

Сталин цагаа гаргаж ирээд, чимээгээ намдах болсныг харуулах гэж дээш нь өргөв. Хариуд нь улам нижигнүүлэн алга ташлаа.

Сталин цагаа тэргүүлэгчид рүү харуулав. Цаадуул нь жолоодогч, ард түмэн хоёрын энэ сэтгэл уярам энгийн уулзалтад адилхан оролцож байгаадаа хөөрчихсөн болохоор түүний өөдөөс малилзан инээмсэглэцгээв. Тэгснээ хурлын тэргүүлэгчид Сталины аргагүй л ардчилсан байдлаар илэрхийлсэн шаардлагад найр тавих мэт суудалдаа сууж эхэлцгээв.

Танхимд хуран цугларагсад ч уван цуван сууцгаасан боловч алга ташсаар байв.

-Нөхөд өө хэмээн Сталин инээмсэглэв. -Урьдчилгаа болгож алга ташихаа азнацгаа л даа, миний юу хэлэх гэж байгааг та бүхэн мэдэхгүй шүү дээ.

Танхим хариуд нь баярлан инээлдэж, дахин хүчтэй алга нижигнүүлцгээв.

-Надад хоёр төрлийн залруулга байна хэмээн Сталин үгээ үргэлжлүүлэв. -Москвагийн метрог амжилттай барьж байгуулсны төлөө нам, засгаас зарим хүнийг Лениний одонгоор, заримыг нь Улаан Таван Хошуу одонгоор, гуравдахь хэсэг нөхдийг Хөдөлмөрийн Гавьяаны Улаан Тугийн одонгоор, дөрөвдэх хэсэг нөхдийг Төвийн Гүйцэтгэх Хорооны жуух бичгээр шагнасан. Гэтэл бусад нөхдийг яах вэ, шагнуулсан хүмүүстэй адилхан хүч хөдөлмөр, авьяас чадвараа гаргасан нөхдийг яах вэ гэдэг асуулт байна. Та бүхний нэг хэсэг их баяртай байх шиг, гэтэл нөгөө хэсэг нь гайхширч байна. Яадаг хэрэг вэ? Асуулт мөнөө дөө.

Тэрээр дуугүй болзнов.

Танхим сүсэглэх мэт нам гүм.

-Тийм болохоор нам, засгийн энэ алдааг бид шударга хорвоогийн нүүрэн дээр залруулахыг хүсч байна гэж Сталин өгүүлэв.

Дахиад танхим дүүрэн инээдэм болж алга нижигнэлээ.

Сталин чимээгээ аядахыг уриалан гараа өргөснөө,

-Би удаан ярих дургүй, тийм учраас залруулгыг уншиж сонсохыг болгооно уу гэв.

Тэгээд энгэрийнхээ халааснаас дөрөв нугалсан цаас гаргаж ирээд задлалаа.

-Нэгдэх залруулга: Москвагийн метрог барьж байгуулах ажлыг амжилттай гүйцэтгэсний учир ЗСБНХУ-ын Төвийн Гүйцэтгэх Хороо, Ардын Комиссарын Зөвлөлийн нэрийн өмнөөс Метробарилгын эрэгтэй, эмэгтэй гавшгайчид, түүнчлэн инженер, техникчид, ажилчид, бүх хамт олонд талархал илэрхийлсүгэй.

Бас дахиад л алга нижигнэлээ.

Бүгд босцгоож, тэргүүлэгчид ч дагалаа.

Энд тэндээс “ура” цууриатуулан хашгирлаа. Энэ алга ташилт, энэ ура зөвхөн өөрт нь төдийгүй, метроны барилгачдад талархал дэвшүүлсэн засгийн газарт, бас энэхүү эрхэм талархлыг зүй ёсоор хүлээсэн барилгачдад өөрсдөд нь хамаарч байгаа учраас Сталин шуугианыг намсгахыг эс оролдон индэртээ инээмсэглэн зогсож байв.

Тэгж тэгж чимээ намдмагц Сталин,

-Метробарилгын бүх ажилтанд бид талархал илэрхийлсэн залруулгыг өнөөдөрт нь багтаан

гаргах хэрэгтэй гэснээ дахин алга ташиж эхэлснийг гар дохин болиулав. -Та нар надад алга таших хэрэггүй, энэ шийдвэр бол бүх нөхдийнх. За, хоёрдахь залруулга, би шууд уншъя гээд өмнөх цаасаа харав: -Москвагийн метрог амжилттай барьж байгуулахад комсомолын яруу алдарт эрэгтэй, эмэгтэй гишүүдийг дайчлан оролцуулах үйлст онцгой гавьяа байгуулсны учир Москвагийн комсомолын байгууллагыг Лениний одонгоор шагнасугай.

Дахиад л тархинд хадам алга ташилт. Энэ удаа Сталин ч өөрөө алга ташиж буй нь Москвагийн комсомолд хүндэтгэл үзүүлсэн хэрэг болой.

Тэгсхийгээд түүнийг алга ташихаа болиход танхим ч нам гүм боллоо.

-Энэ залруулгыг бас өнөөдрийн дотор гаргаж, маргааш нийтлэх хэрэгтэй... Энэ чамлалтай байж магадгүй, гэвч бид илүү юм бодож олж чадсангүй шүү, нөхөд минь. Өөр ямар нэгэн зүйл хийж болохоор бол та бүхэн хэлж өгөөрэй.

Сталин хурлынхан руу гар дохин талархаад тэргүүлэгчдийн байр руу зүглэв.

Түрүү түрүүчийнхээс илүү уухай мандлаа. “Хайрт Сталинд-ура!” Тэгтэл ч “Ура!”, “Ура!”, “Ура!” гээд танхим тэр чигээрээ нүргэлээд явчихлаа. Нэг бүсгүй сандал дээр үсрэн гараад “Нөхөр Сталинд-комсомолын ура!” гэж хашгирлаа. Бас дахиад л эгнээ дамжин “Ура!”, “Ура!”, “Ура!” хэмээн түрэв.

Арваад минут уухайлан түрцгээлээ. Хурлынхан зогссон чигээрээ алга ташин, “Ура”, “Хайрт Сталинд-Ура!” хэмээн хашгиралдсаар.

Сталин тэргүүлэгчдийн байранд чимээгүй зогсоод танхимыг харж байна. Үгүй ээ, эд нар бол бүтэн хагас жилийн өмнө Арвандолдугаар их хурал дээр алга ташигсад биш, тэд нар өнгөн дээрээ ташиж байсан, эд нар бол түүний хүмүүс.

Залуучууд төрөлх чанараараа тогтворгүй гэдэг нь гарцаагүй. Залуу хүмүүс ч яваандаа бас аргина, шинэ үе өсөн гарч ирнэ, тэдэнд бас зам тавьж өгөх хэрэгтэй, энэ бол тасралтгүй үргэлжлэх эмзэг үйл явц.

Гэхдээ боловсон хүчний шинэчлэл бол зайлшгүй тохиох үйл явц, гагцхүү, удирдлагад орж ирэх боловсон хүчин түүний л боловсон хүчин байвал зохино. Шинэ боловсон хүчнүүд эрх мэдлийг булаан авахдаа засаглал хөдөлбөргүй бат бэх гэж итгэдэг учраас тэдгээрийн өмнөх хүмүүсийг устгачихсан тухайд төдийлөн тогтож боддоггүй. Тэгээд өөрснөө бас зайлахын цаг болоход өрсөлдөгчдөө буруутгахаас биш нөхөр Сталиныг үүнд буруутгахгүй. Нөхөр Сталин тэдний хувьд Засгийн өндөрлөгт гаргасан хүн гэдгээрээ л үүрд үлдэнэ.

Сталин баяр бахдалдаа мансуурсан, дэвэрч хөөрсөн танхимыг ажиглах зуур ийнхүү боджээ.

Нээрэн, эд нар түүнд чин санаанаасаа үнэнч байгаа, хязгааргүй бөгөөд эцсээ хүртэл үнэнч байна. Тэрээр дахиад ямар нэг юм хэлэх хэрэгтэй, энгийн өөриймсөг ямар нэг юм хэлж хүн болгоны сэтгэлийн учигт хүрэх хэрэгтэй, зөвхөн сүр хүчээрээ төдийгүй энгүүн хээгүйгээрээ эднийг эзэмдэх хэрэгтэй.

Тэгж тэгж алга ташилт эрхбиш намдахуйд мань хүн аяархан хэрнээ хэнд ч сонсдохоор,

-Та бүхэн юу гэж бодож байна, залруулга ингээд болох уу? гэж асуулаа.

Алга ташилт дахин шинэ эрчээр нижигнэх нь тэр.

Цөмөөрөө босцгоолоо.

Тэргүүлэгчид зогсоогоороо алга ташиж байна. Сталин, Молотов, Каганович, Ворошилов, Оржоникизе, Чубарь, Микоян, Ежов, Межлаук нар шүү дээ. Энэ байдал эцэс төгсгөлгүй удаан үргэлжлэв. Хуран цугларагсдын хувьд өнөөдөр бол чухамхүү тэдний өдөр, Сталиныг нүдээр харах насанд нь ганц тохиох өдөр ч байж магадгүй болохоор тэд нар байрнаасаа ч хөдөлж чаддаггүй, явж ч чаддаггүй, Сталинаас ч салж чаддаггүй, нэгэнт тохиосон баярыг сунгаж, Сталиныг дахин дахин сонсох чин хүсэлдээ авгжээ.

Гэтэл Сталин хэлэх үгээ хэдийн хэлчихсэн, дахиад үг хэлэхгүй, нэгэнт байдал иймдээ тулсан учир хэн нэгэн хүн “Кагановичийг!” гэж хашгирлаа.

Тэгтэл ч танхим “Кагановичийг!”, “Кагановичийг!” хэмээн түүнийг дор нь түрэн авамхайлав.

Каганович самгардан Сталин руу зэрвэсхэн хяламхийв. түүний дараа үг хэлэх гэж үү?

Гэтэл Сталин,

-За, Лазарь, ард түмэн хүлээж байна, ард түмэнтэй ярилц л даа гэж хэлэв.

Каганович индэр рүү очлоо.

Сталин Баганат танхимын хурлын дараа Кремлиэр дайралгүй Кунцево дэх шинэ зуслан руугаа яваад өгчээ. Ой цэцэрлэгийн дундах хөнгөн маягийн нэг давхар энэ байрыг ноднин Мержанов барьсан юм. Дээврийнхээ энгээр наранд шарах талбайтай. мань хүн тэр талбайг ашигладаггүй ч гэсэн байж байг, сэтгэлд таарахгүй бол дээр нь нэг давхар нэмээд барьцгаана биз хэмээсэн. Зуслангийн байшин үйлчилгээний байртай хүзүүвчээр холбоотой.

Бэлэн болчихоод түүнийг хүлээж байсан байшинд Сталин анх удаа ирж байгаа билээ.

Хамаатан садан гэгдэх баахан хүн шавчихсан, ёстой могойн үүр гэлтэй Зубалово дах байрнаас эцсийн бүлэгт хоёр яс салах нь энэ. Хамаатан гэгдэгчид нь Надягийн үхэлд буруутган өөрийг нь одоо хэрнээ уучлаагүй өвгөн, эмгэн хоёр Аллилуев, тэдний нэг муу хүү Павел, тэр этгээд л Надягийн өөрийгөө буудсан гар бууг талийгаачид бэлэглэсэн ухаантай юм, Надягийн эгч Аня гэж нөхөр шуу юмандаа ухаан тавьчихсан, бүдүүн боольхой тэнэг толгой, нөхөр нь Реденс гэж хавьтсан болгонтой хонож явдаг сайхан эр, гэхдээ хэрцгий, овилгогүй, сэхүүн зантай польш энэ тэр.

мань хүн бас анхныхаа авгай Екатеринагийн хамаатан Сванизегийн ам бүлийнхнийг үзэж чадахгүй. Ер нь яривал хүүхэндээ ч гэсэн хайртай байгаагүй. Дуу шуу цөөнтэй, номхон дуулгавартай ч сүсэгт автсан, богино жолоотой, тэр аяараа өөрт нь харшлам мөхөс хүүхэн. Өөрийг нь хувьсгалаа орхиод хуврага болно гэж горьдсныг бодоход юу ч ойлгохгүй байсан хэрэг дээ. түүний дүү хүүхэн хүү Яшаг нь бас яг тийм хүн болгож хүмүүжүүлсэн. Дуугаа хураачихсан, элэг буруутай бандь. мань хүн түүнийг нарийн яривал олигтой мэдэхгүй, сайн хараа ч үгүй билээ. Гэтэл тэр Яшаг хүр дүү Алеша Сванизе Москвад аваад ирдэг байгаа даа.

Яах гэж авчрав? Сургуульд суух юм гэнэ! Тифлист дээд сургууль байхгүй юм уу? Үгүй ээ, ном үзүүлэх гэж л лав авчраагүй. түүнийг хүүхдийнхээ хувь заяаг сонирхдоггүй, боловсролынх нь талаар санаа тавьдаггүй гэдгийг л цохон харуулах гэж авчирсан. Тийм учраас л тэр тухай нагац ах Алеша Сванизе нь санаа тавихад хүрч байгаа байх нь л дээ.

мань хүн шинэ гэр бүлтэй юм чинь. Дагуул хүүхдийг ам бүлдээ оруулахын хэрэг юу байна? Элэг буруутай, хайргүй, оросоор муу ярьдаг хүүхдийг шүү! Энэ бол түүний гэр бүлийн эв түнжинг эвдэх, түүний гэр бүлийг сарниулах, түүний гэрт өөрийн төлөөний хүнийг байлгах гэсэнээс өөр юу байхав. Бүх юмыг нарийн тооцоолсон байгаа юм. Хэрэв Яшаг буцаагаад явуулчих юм бол улс амьтан Надя л түүнд нүүр өгсөнгүй гэгцгээнэ. Надя их ёсорхуу байсан шүү дээ, улс амьтан юу гэж хэлэх нь түүний хувьд амин чухал зүйл!

Хүр дүү Алеша Сванизе түүнд ийм л сонин бэлэг өргөн барьсан. Гэтэл тэр бэлэг нэгээр тогтохгүй. Төрсөн хүүдээ ЖОНРИД гэдэг нэр өгсөн. Ямар вэ дээ?! Ямар нэр бодож олж байна аа! 1929 онд шүү! Гүрж нэр үү? Орос уу? Үгүй ээ, орос ч биш, гүрж ч биш. Жон гэдэг ойлгомжтой. Тийм англи нэр бий. Рид? Бас байдаг байж болох юм. Гэхдээ Жон Рид гэдэг бол овог нэр хоёр шүү дээ. Нөгөө Октябрийн бослогын түүхийг гуйвуулсан, Троцкийг хэт дөвийлгөж магтсан, өөрийг нь, Сталиныг нэг ч удаа дурсаагүй хуурамч номны сүгийг бичсэн Жон Ридийн овог нэр. Энэ муу номонцорыг номын сангуудаас хураасан, түүнийг хадгалсан

хүмүүс таван жилийн хорих ял авч байгаа. Гэтэл түүний хүр дүү Алеша Сванизе энэ нэрийг төрсөн хүүдээ өгсөн байгаа юм. Жон Рид гэж хэн болохыг мэдэхгүй хэрэг үү? Сайн мэднэ. Сэхээтэн. Боловсролтой. Тифлисийн шашны сургуульд биш Германд, Иена хотод ном үзсэн хүн. Европын төдийгүй дорно дахины хэлнээс мэднэ, Менжинскийрхүү олон хэлтэй, тийм учраас бүхнийг ойлгоно, тэгээд л түүнд хорон санаалж хүүдээ тийм нэр өгсөн. Мария Анисимовна гэдэг дуурийн дуучин хүүхэнтэй ханилсан, тэр нь дууриа хаяад Берлинд худалдааны төлөөлөгчийн газар нөхрөө дагаад оччихсоныг бодвол шалихгүй дуучин байж л дээ. Хилийн чанадаас Надяд элдэв хувцасны сүг авчирч өгнө, түүний гэргийг гадаадын үжир новшинд зугуухан дасгаж, улс төр, ёс суртахууны хувьд ялзруулж байсан. Бүх юмыг зориуд хийдэг хорон санаатай, жөтөөрхүү хүмүүс. Гэхдээ аймхай. Алеша бильярд тоглохоороо түүнд дандаа хожигдоно, дараа нь найз нартаа “Би хожих юм бол мань хүн хариуд нь өөр хүний толгойг авчихна” гэж тайлбарлана.

Нөгөө эрхэм Алеша Сванизе чинь өөрийнх нь нүднээс далд ийм юм ярьдаг, ингэж олны өмнө түүнийг доромжилдог этгээд!

Бас яахаараа Аллилуевынхан Сванизегийнхан хоорондоо халуун дотно нөхөрлөж байна? Анхны авгайн хамаатнууд, дараачийн авгайн хамаатнууд чинь бие биенийгээ ад үзэх ёстой баймаар. Аллилуевынхан Яшаг хайрлаж чадна гэж үү? Эсвэл Сванизе Вася, Светлана хоёрыг хайрлаж чадах уу? ӨӨРИЙГ нь үзэн ядах нийтлэг үзэл л тэднийг нэгтгэж байгаа. Тэднийг нэгтгэж байгаа юм яг энэ.

Одоо ингээд гүйцээ! Тэрээр Зубаловын байр руу дахиад хэзээ ч шагайхгүй. Түүнгүйгээр тэндээ аж төрцгөөг, тэгээд өөр хоорондоо хэмлэлдэцгээж байг. Тэд нар хэн нэгнийг мэрж байх албатай юм бол бие биенээ мэрцгээж байг.

Сталин хаврын адаг сарын бүлээн наранд цэцэгсийн сайхныг бахдан цэцэрлэг дундуур холхив. Зарим цэцэг цоморлигоо хараахан дэлгээгүй байхад зарим нь дэлгэрэхээрээ нэг дэлгэрчээ. Газар шороо зөвхөн үржин төлжих, зөвхөн үр жимсээ өгөх төдийгүй нүд баясгаж байх ёстой. Цэвэрхэн жим зөрөг, хөөрхөн хөөрхөн асар, жижигхэн ширээ, сүлжмэл хэвтэц, аравчтай эвхмэл сандал бүхий задгай талбай энэ тэртэй сайхан тордсон цэцэрлэг Сталинд таалагджээ.

Нам гүм, амар жимэр. Энэ бол хөл үймээн, хэрүүл уруул, хов живэндээ хутгалдсан Зубалово биш. Ялангуяа хадам эх Ольга Евгеньевна гэж нэг яншаа, хэрүүлч чавганц үйлчилгээний ажилчидтай хэзээ мөнхөд хэрэлдэнэ, тэднийг өөрөө “албаны хүмүүс” гэх бөгөөд аж ахуйч биш байна, улсын хөрөнгийг үрэн таран хийж байна хэмээн зэмлэж, бараг л хулгайлж хумсалдагт нь хүрээд зогсохгүй нярав, тогооч, зөөгч энэ тэрийг харааж зүхнэ. Зүгээр ч үгүй ӨӨРИЙНХ нь нүүрэн дээр тэгж авирлана, үүнийг чинь үйлчилгээний ажилчидтай ингэж харьцахыг мань хүн сайшааж байгаа юм байна гэж хүмүүс бодож болно оо доо.

Үйлчилгээнийхэн түүнд дургүй, нүднээс нь далд бол “солиотой чавганц” гэгцээнэ, мань авгай үнэндээ ч солиотой л доо, нэг бол хашгирч гуугалаад байна, тэгснээ гэнэтхэн эвийлээд хөөрхийлөөд явчихна, нэг бол харууслын нулимс асгаруулна, нэг мэдэхэд баярын нулимс мэлмэрүүлнэ, эсвэл хүүхдийг яаж хүмүүжүүлж байгааг шүүмжлээд явчихна, за гол нь, хамгийн хэцүү нь ам хамхихгүй шуугина, тэсэхийн аргагүй шуугина.

түүний эцэг украин, гүрж хоёрын эрлийз, эх нь Магдалина Айхгольц гэдэг герман хүн, герман цагаачдын удам. Хадам эх гүрж аялгуутай ярьдгийн гадна “Вайме, швило, генацвале, чириме” гэхчилэнгийн гүрж үг хавчуулна. Тэгснээ гэнэтхэн германаар “Майн готт” гэнэ! Жигтэйхэн зэвүүцэж хоёр гараа тэнгэр өөд сарвайж ирээд л “Майн готт” гэж уулгална. Энэ “Майн готт” л мань хүргэний тархиар нь татаад авах шиг болж үнэн дургүйг нь хүргэнэ.

Өвгөн Аллилуев Сергей Яковлевич бол зөнөг дүйрэн. Зубаловод дархны газар нээж олон багаж, ширээ, элдэв төмөр цуглуулчихаад зорно, харуулдана, гагнана, өөрийн болон хөрш зуслангийнхны цоожийг засна. Уг ухаан нь нөгөө жинхэнэ пролетар, “ажлын гар”, “алтан гар” байх нь л дээ.

түүнийг зусландаа иртэл, хаанаас ч юм, нэг охин гарч ирээд Сергей Яковлевичийг очиж цоож засч өгөхийг гуйж явна гэх.

Үгүй ер?! Ямар вэ дээ?!

мань хүн сэхээвчинд сууж байтал хөршийнх нь охин түүнээс асууж байна: “Сергей Яковлевич хаа байна?” - “Чи Сергей Яковлевичээр яах нь вэ?” - “Цоожоо засууль”. түүний зусланг слесарийн газар болгочихож! Гэтэл ятгаад ойлгуулна гэвэл гонж. Биеийн хөдөлмөр хүнийг ариусгадаг юм байж л дээ. Идеалист марксчидын нэг. Ахмад большевикуудын нийгэмлэгийнх. Тэд нартайгаа хуралдаж, тэд нар шигээ айварлана. Дурсамж бичнэ. Өдрийн хугас бусдын цоож засна, үлдсэн хугаст нь дурсамж бичнэ.

Ахмад большевикуудын нийгэмлэг гэж юу юм бэ? Өтгөсийн асрамжийн газар! Нэгдүгээр сард болсон Зиновьев, Каменевыг шүүх ажиллагааны үеэр бухимдацгааж, тэр ч байтугай ямар нэгэн шийдвэр гаргах гэж оролдоцгоосон. Ваня Будягин онцгой чармайж байсан. Ахмад большевикуудыг шүүж болохгүй гэж. Яагаад болохгүй билээ? Троцкийг хилийн чанад руу цөлж байхад, Иван Никитич Смирнов, Смилга, Раковский болон бусад троцкийчуудыг шоронд хийж байхад эрхэм хүндэт Ваня яагаад бухимдаагүй билээ? Нөгөө Зиновьев, Каменев хоёрыг нь цөллөгт явуулж байхад бас? Тэгсэн мөртлөө Кировын хэргийг болохоор эсэргүүцсэн. Чухам яагаад Кировынхыг? Кировын хувийн найз хүн чинь ёстой хайр найргүй баймаар юм, гэтэл мань хүн түүний алуурчид, тэдний зоригжуулагчдыг шүүхийн эсрэг байсан. Ямар нэг юм мэдэж байна уу? Нэг юм гадарлачихаа юу? Бусдаар захиа бичүүлэх, эсэргүүцэл илэрхийлүүлэх, шийдвэр гаргуулахаар турхирч байсан. Тэд эмээцгээсэн.

Муусайн шаарнуудын үүр! Ямар ач тус өгч байна? Яагаад намаас тусгаарлаад байна? Ахмад большевик хэмээгдэгчдэд тусгай нөхцөл бүрдүүлэхийг хүсцгээж байна, өөрсдийгөө большевикуудын уламжлалыг төлөөлөх цорын ганц төлөөлөгчид, Лениний өвийг сахин хамгаалагчид байлгахыг хүсцгээж байна, намын дээд шүүх, намын “нинжин сэтгэл” болохыг хүсцгээж байна. Намын нэгдлийг хамгаалагчид байх юм гэнэ. хэнээс хамгаалж байна вэ? Тэд нар намыг бус, өөрсдийгөө хамгаалж байна. Тэд нар дор бүрдээ дөрөвний гурван хувийн хуучин троцкийчууд, зиновьевчууд, бухаринчууд, нугалаачид, зүсэн бүрийн сөрөг хүчнийхэн.

Ахмад большевикууд хэмээгдэгч нар өөрсдийнхөө хүчийг эв нэгдэл, ган бат нягтрал, бие биенээ хаацайлахад байгаа гэж итгэж байна. Эндүүрэл. Чухамхүү тэдний сул тал эндээ байгаа юм. Тэд нарын ажил хэрэгч харилцаа, ажил төрлийн холбоо, намын гишүүдийн

харьцаа, нөхөрсөг харилцаа гэж нэрлээд байгаа хэлхээ холбоо нь гэмт хэлхээ холбоо болж таарна. Олон хүнийг сэжиглэхэд нэгнийх нь мэдүүлэг хангалттай, бүгдийг нь буруутан болгоход хэдэн хүний мэдүүлэг хангалттай.

Одоогоор дуугаа хураацгаачихаад байна.

Чимээгүй байх чинь бас л эсэргүүцлийн нэг хэлбэр.

Хэвлэлийн газар нь юу нийтэлж байна гээч? “Ахмад большевик” эмхэтгэл, албан мэдээлэл. Тэд тэнд юу бичиж байна? Өөрийнхөө түүхийг бүтээж байна. Намд хэрэгтэй түүхийг биш, зөвхөн өөрсдөд нь хэрэгтэй түүхийг. Тэр түүхэнд нь юуны өмнө нөхөр Сталинд эзлэх байр байхгүй. Учир юу гэвэл тэр нь хувийн дурдатгал, дурсамж юм гэнэ.

Тийм дурдатгал, тийм дурсамж намд хэрэггүй. Аливаа дурсамж түүхийг гуйвуулна. Дурсамжийг зөвхөн өөрийнхөө оролцсон юмыг мэддэг хүн, өөрөөр хэлбэл, нийтлэг зүйлийг мэдэхгүй, зөвхөн тухайн зүйлийг мэддэг хүн бичнэ. Нийтлэг мэдлэг хомсхон учраас дурсамж бичигч уран зөгнөлд арга буюу автана, тэгснээс болж бас л үйл явдлыг гуйвуулахад хүрнэ. Дурсамжийн зохиол бүтээл эдгээр дутагдлаасаа болоод намын түүхэнд ашиглах үндэсгүй хортой зүйл болж хувирна.

Энэ ахмад большевикууд хэмээгчид өөр юу хийцгээж байна?

Хэрэлдэж маргалдана, гавьяа зүтгэлээрээ уралдацгаана, хаант засгийн нууц цагдаагийн албаныхантай сүлбэлдэж байсан гэж бие биенээ буруутгана, ингэснээрээ ахмад большевик гэдэг эрхэм нэрийг л гагцхүү гутааж байна. Тэдний хэрүүл уруул, тэдний маргаан тэмцээний учрыг авч хэлэлцэхээс өөр аргагүйд хүрч байна. Намын Хянан Шалгах Хороо зөвхөн ийм л ажилтай болчихлоо. Тэдний хэрүүл маргааныг шүүхээс өөр ажил нөхөр Емельян Ярославскийд байхгүйсэн бил үү?

Чингэхэд нөхөр Емельян Ярославский энэ нийгэмлэгийн дарга. Ахмад большевикуудын нийгэмлэгийн дарга байх нь мэдээж хүндтэй, гэхдээ энэ нийгэмлэг хэнд хэрэгтэй вэ гэдгийг нөхөр Емельян Ярославский бодох л ёстой байсан даа. Энэ нийгэмлэг хэнд, юунд үйлчилж байна вэ? гэдгийг.

Дашрамд хэлэхэд, хүндэт нөхөр Емельян маань түүнээс гадна хуучин улс төрийн тарчилгынхан, цөлөгдөн суурьшигсадын нийгэмлэгийн ахлагч. Емельян Ярославский цөлөгдөн суурьшигчийн гэр бүлд Чита хотод төрсөн юм чинь энэ ч бас л хүндтэй л дээ. Гэхдээ л энэ нийгэмлэг хэнд хэрэгтэй вэ гэдгийг нөхөр Емельян бас л бодох ёстой байсан. Бас л өтгөсийн асрамжийн газар, гэхдээ бүр меньше-викүүд, эсерүүд, анархчууд, цаашилбал өөрснийгөө улс төрийн хэрэгтэн болгочихсон зүгээр л хуучин эрүүгийн ялтангуудын асрамжийн газар. “Тарчилгаа ба цөллөг” гэдэг сэтгүүл гаргана, хэний тухай бичдэг гээч? хэний нэрийг дурдаж байна? Улсын хэмжээгээр бараг тавь шахуу салбартай, ямар хүмүүс тэнд байдаг байна аа? Энэ байгууллага юунд хэрэгтэй вэ? Зөвлөлт засгийн учир битүүлэг дайснууд, тэрс улс.

Энэ тухайд нөхөр Ярославский өөрөө юм бодог, ахмад большевикуудын нийгэмлэг, улс

төрийн тарчилгынхан, цөлөгдөн суурьшигсадын нийгэмлэг, аль алинийг нь татан буулгах тухай санал өөрөө Төв Хороонд оруулаг. Нөхөр Сталин ахмад большевикуудаас хоёр яс салж байна гэж хэн хожим хэлж чадах вэ? хэн ч хэлж чадахгүй...

Ярославский ухаантай хүн, бүх юмыг яаж жин тан болгохоо андахгүй. Хорин найман оны долдугаар сард Төв Хорооны Бүгд хурал дээр Крупскаяг сайхан чимхсэн: “Сталин өөрийг нь гомдоолоо гэж бие муу Ленинд гомдол мэдүүлэхдээ хүрч байна гэнэ ээ. Шившиг! Ийм том асуудлаархи улс төрийн бодлоготой хувийн харилцаагаа хутгаж болохгүй”

Сайн хэлсэн шүү. Крупскаяг чимхээд зогсоогүй, нөгөө нэг золигийн явдалд тодотгол хийсэн, чухамхүү х э р э г т э й тодотгол хийж, жинхэнэ буруутныг нь илчлэхийн хамт, бие муу Ленинийг тайвшруулахын тулд бүгдийг өөртөө хүлээж уучлал гуйсан нөхөр Сталины нүнжигийг, түүний нүнжигийг цохон харуулж өгсөн. Эр хүн!

Ярославский намын дотор нэр хүндтэй, тэргүүлж магнайдах гэж өрсөлдөхгүй. Гадагшаа цагаачилж үзээгүй, оросын үндсэн практикийн большевик. Намын дотор з а р и м н э г ийм нэрийг хадгалж үлдэх хэрэгтэй. Их сургууль, гимнази энэ тэр төгсөөгүй ч аливаа бие даан сурсан хувьсгалчдын адил болосролтой, намын түүхээр найруулал бас бичнэ, жинхэнэ удирдагчийн үүргийг түүхэнд яаж гаргах хэрэгтэйг ойлгоно, гүйцэд ойлгохгүй байсан явдал бий, 1931 онд түүнийг яльгүй сэнхрүүлэх, эелдэг байдлаар сэнхрүүлэх хэрэг гарсан. “Харамсалтай нь, энэ дүгнэлтэд бас нөхөр Ярославский ч хамаарна. түүний БХК (б)Н-ын түүхээр бичсэн ном товхимлууд хэдийгээр өөрийн гэх сайн талтай ч тэнд түүхэн болон зарчмын шинж чанартай нэлээн олон алдаа бий”. Гоморхоогүй. Бүгдийг ойлгосон. Тэгэхээр энэ өтгөсийн асрамжийн газруудтай холбогдсон асуудлыг ч бүгдийг ойлгоно. Ахмад большевикуудын нийгэмлэгийг татан буулгана, харин ахмад большевик Емельян Ярославский үлдэнэ.

Сэрүү татаж эхэлсэн тул Сталин байшиндаа орлоо.

Тэрээр арын том өрөөг ажлын ч өрөө, унтлагын ч өрөө, түүгээр ч барахгүй гаднын зочин байхгүй үед хоолны өрөө болж чадахаар тавилга тавьж тоноглохыг тушаасан билээ. Зөвхөн ажлаа алдсан хүмүүс л өрөөнөөс өрөө хэсэн сэлгүүцэх дуртай, харин ажилтай хүний хувьд бол хамаг юм нь гар дор нь байх ёстой.

түүний унтдаг буйдангийн хажууд харилцуур утастай жижгэвтэр ширээ, эсрэг талын хананд сав суулгатай шүүгээ бий, тэр шүүгээний нэг татуурганд чухал хэрэгцээтэй эмнүүд байгаа. Бичгийн ширээ тавихыг Сталин зөвшөөрөөгүй, бичгийн ширээ өрөөг албан маягтай болгочихно, энэ бол байгууллага биш айлын гэр. Нөгөөтэйгүүр мань хүн сонин сэтгүүл, элдэв цаас тавиастай том ширээнд суугаад ажлаа хийж болно, өглөөний цай, өдөр, оройн хоол ирэхээр энэ л ширээнийхээ нэг зах дээр бүтээлэг дэвсчихдэг юм чинь.

мань хүнийг сая орж ирэхэд ч Зубаловод ажиллаж байсан Валечка гэдэг залуухан ялдам цовоо үйлчлэгч хоолны ширээг нөгөө байдлаар нь зэхэж байв.

-Сайн байна уу, Иосиф Виссарианович оо, би танд оройн хоол авчирлаа.

Хүүхэн түүнийг урьдын адил сүсэглэсэн үнэнч харцаар ширтэх аж.

-Баярлалаа гэж Сталин хариулав.

Уул нь Зубаловогийн үйлчилгээний хүмүүсээс Кунцево руу нэг ч хүн битгий ав гэж Тэрээр Власикт тушаасан шүү дээ.

Валечка бүгдийг нь алчуураар сайхан бүтээжээ.

-Хагас цагийн дараа аваарай гэж Сталин хэлэв.

-Өө, за! Ёсоор болгоё.

Валечка гарлаа.

Сталин оройн зоогоо барив. Тэрээр тун бага иднэ. Талхнаас жижигхэн хэлтэлж аваад тос түрхэх аядав. Хундага хуурай дарс, бас хагас аяга шингэхэн цай уулаа. Сонинуудаа гүйлгэн харав.

Яг хагас цагийн дараа Валечка ирлээ.

-Иосиф Виссарианович та хоолоо идчихэв үү?

Тэгээд Сталинд үйлчилж байгаадаа жаргалаа эдлэсэн энэ эвлэгхэн энгийн хүүхэн түүн рүү түрүүчийн адил цовоолог үнэнчээр харлаа.

-Тэглээ, баярлалаа.

Валечка ширээн дээрээс бүх юмаа эмхлэн авч тосгуур дээр тавьснаа Сталин руу харж нэгэнтээ инээмсэглээд, сунгасан гар дээрээ тосгуураа барьсаар хаалга руу зүглэв.

-Власик над руу ирэг! гэж Сталин тушаалаа.

-Өө, за! Ёсоор болгоё.

Сталин сонингоо гүйцээгээд босч өрөөн дотуураа хэд алхав.

Шалан дээр нэг хивс дэвсээстэй, бас нэг хивс буйдангийн ард өлгөөтэй байна. Энэ хоёр хивс, дээр нь задгай зуух гээд түүний хамаг тансаг хэрэглээ дуусах нь тэр.

Хаалга нээгдсэн нь босгон дээр Власик зогсож байв.

Сталин руу бүлтийхээрээ бүлтийчихээд “номхон” зогсолтоор зогсож байх аж.

Сталин түүн рүү зөвхөн өөрөөс нь өөр хэн ч харж чаддаггүй харцаараа нэгэнтээ харлаа.

Власик үхсэн амьдын хооронд зогссоор.

Сталин өрөөгөөрөө дахин хэд алхсанаа буцаж ирээд Власикт тулж зогсов.

-Зубаловын үйлчилгээний хүмүүсээс нэг ч хүн нааш нь бүү шилжүүл гэж би танд тушаасан.

-Тийм ээ, нөхөр Сталин, та тушааж байсан.

-Яагаад зөрчив?

-Нөхөр Истомина Валентина Васильевнагаас өөр хэнийг ч шилжүүлээгүй, нөхөр Сталин.

-Яагаад миний зөвшөөрөлгүй тэгэв?

-Та яг эзгүй байсан юм, нөхөр Сталин. Бид тэгээд, цуглаад, хэлэлцээд зөвхөн нөхөр Истомина Валентина Васильевнаг шилжүүлэхээр шийдсэн, учир нь тэр, өөрөөр хэлбэл, Истомина Валентина Васильевна яаж хоол барих, яаж хураахыг мэднэ. Шалгагдсан хүн.

-Та хэнтэй цуглаж, хэнтэй хэлэлцэж, хэнтэй шийдэв?

-Нөхөр Паукертэй.

Сталин эргэж, сэхээвч рүү гардаг шиллэсэн хаалга руу очоод цэцэрлэгийг хэсэг харав.

-Том хурал байна... Тэгээд удаан хэлэлцэв үү?

-Тэгсэн гэж эхэлснээ Власик чимээгүй болчихов.

Сталин хаалганаас холдож ширээн дээрх бэхний савыг шилжүүлэн тавив.

-Та нар үүнийг хэдэн цаг хэлэлцсэн юм бэ гэж би асууж байна, нэг цаг уу, хоёр уу, гурав уу?

-Нэг цаг хэмээн Власик сонсдох төдий өгүүлэхдээ “нөхөр Сталин” гэж нэмж хэлэхээ мартчихжээ.

Одоо Сталин Власик руу яг тулгаж харлаа.

-Та цайлган сэтгэлтэй, тэгээд Истоминаг нааш нь шилжүүлчихэж, би болохоор хар санаатай, тэгээд түүнийг эндээс зайлуулах ёстой байх нь ээ?!

Власик дуугарсангүй.

-Би түүнийг зайлуулах ёстой юу? гэж Сталин давтан асуув.

-Юу гэсэн үг вэ, нөхөр Сталин, би үүнийг чинь нүд ирмэхийн зуур... гэж Власик гүвтнэв.

-Нүд ирмэхийн зуур?! хэмээн Сталины уур шатчих нь тэр.

-Мануухай! Мануухайгаас болж би хүн хөөх ёстой юу?! Чам шиг тэнэг толгойг хөөсөн нь надад дээр... Цуглаж, хэлэлцэж, шийдэж гэнэ... Дүйрэнгүүд!

Сталин сэхээвчийн шиллэсэн хаалга руу дахиж очоод эргэж харалгүй,

-Яв! гэж зандрав.

Адайр ааштай, харанхуй мөхөс цэргийн дарга Николай Сергеевич Власик энэ шөнө анх удаа зүрх нь зовиурлаж хоножээ. Харин ямар ч сэжиг ажиг аваагүй Валечка Сталиныг нүд анин анигал Кунцевоод ажиллажээ.

Арын өрөөтэй залгаа сэхээвчний баруун талаас цэцэрлэг рүү шууд гардаг хаалгатай. Нарны сүүлчийн туяа голт борын бутны завсраар зовхислон цацрана. Сталин шинелиэ нөмрөөд сэхээвч рүү дахин гарч тохойвчтой сандал дээр суулаа.

Зубаловоос аль хэдийн явчихдаг байж дээ.

Надягийн үхлийн дараа Тэрээр Кремлийнхээ байрыг сольсон боловч зуслангийн байр руу нүүхээ яараагүй нь дэмий болжээ. “Ойрын” зусланг барьж байх хооронд “алсын” зуслангуудын алинд ч очиж байхад болох байсан, Зубаловог л ярих юм биш.

Дээхнээ, Надяг амьд сэрүүн байхад мань хүн энэ хамаатан садныг нь эрхбиш тэвчдэг байсан, харин үхлээс нь хойш тэндхийн бүх юм түүнийг санагдуулаад амаргүй. Нэмэрт нь хамаатнууд нь бас л түүнийг санагдуулна. Хөгшчүүлийн харцнаас зэмлэх байдал байнга мэдрэгдэнэ.

Надя яах гэж тийм хэрэг тарив даа?

мань хүнийг бэрх араншинтай гэгцгээдэг. Суут хүмүүсээс хэн нь зөөлхөн араншинтай байлаа? Хөнгөн араншинтай суут гэж байдаггүй юм. Жинхэнэ араншин бол хэзээ ч бэрх араншин байна.

мань хүн ямар лут тэмцэл явуулж байгааг Надя харж байсан, түүн рүү яаж дайрч довтолж, яаж гүтгэн гүжирдэж, яаж далдуур явуулга хийж байсныг харж байсан, эсвэл ямар улсыг мань хүн өвлөж авсан, одоо я м а р улсыг байгуулах ёстойг ойлгодоггүй байсан юм уу?! Ойлгохыг хүсээгүй юм чинь! Петербургийн гимназийн ямар сурагч байлаа, тэр чигээрээ л бэртэгчин айлын гимназийн сурагч хэвээр үлдсэн.

Жинхэнэ язгууртан эмэгтэй бол хэзээ ч тийм юм хийхгүй. Хаан хүмүүс зөвхөн хааны ургийн хүүхэнтэй гэрлэдэг нь санамсаргүй хэрэг биш, тэр хүүхнүүд бол хаан ширээний ашиг сонирхол юунаас ч дээгүүр гэдэг о й л г о л т ы г эхийн сүүтэйгээ хамт биедээ шингээж авна.

Германы ядуурсан гүнтний охид хүртэл үүнийг ойлгодог шүү дээ. Х а а н ч л а х гэж юу байдгийг ойлгодог учраас хаантан эр нөхрийнхөө хажуугийн хүүхэнтэй самуурахаас авахуулаад харгис балмад авир хүртэл бүх юмыг нь уучлана. Нэгдүгээр Екатерина жирийн зарц хүүхэн байсан, түүний хатан хаан гэж юу байхав? Меншиков түүнийг санааныхаа зоргоор дөрлөж хөтлөдөг байсан. Тэгвэл хоёрдугаар Екатерина хэдийгээр багашигхэн

язгууртны сурвалжтай ч гэсэн өөрөө бүх юмыг удирдан жолоодож байсан.

Амиа хорлож байх ч гэж! Ямар хааны авгай тэгэх байсан бол? Хаа ч, хэзээ ч ийм явдал болж байгаагүй. Хаанчлал гэгч юу болохыг ойлгоцгоож байсан хэрэг! Хаан нөхөртөө хир халдааж эс зүрхлэнэ. Тэр ч атугай гянданд ч хийсэн бай, сүм хийдэд ч өгсөн бай, тэнд амиа хорлож байгаагүй.

За, яахав, Надяд ихэс дээдсийн хаялага байгаагүй, ӨӨРИЙНХ нь ач холбогдлыг ойлгоогүй, түүнийг у д и р д а г ч д ы н н э г л гэж үздэг байсан, Кремльд тийм “удирдагчдыг” харсаар байгаад дасчихсан, түүний үүргийг ойлгоогүй, өөрийнхөө үүргийг ч бас ойлгоогүй. Нэмэрт нь тэр академи шүү юмандаа элдэв чалчаа үг ханатлаа сонссон. түүнд тэр академи хэрэг болж гэнэ, хиймэл мяндасны факультет гээд байгаа шүү! Ямар вэ! түүнд хиймэл мяндас мөн ч их хэрэг болно доо! Авель гэж нэг муу хүний адаг л ятгачихсан юм. Тэнд элдэв сөрөг үзэлтнийг дөжиртлөө сонссон. Яаж тэднийг сонсож зүрхэлж байна аа?! Тэднийг заяа нь сонсох ёсгүй байсан! Тэр элдэв яриаг таслан зогсоох ёстой байсан! түүний тухай өөртэй нь огт ярьж зүрхлэхгүй байхаар тэдэнтэй харьцаж байх ёстой байтал харин ч болвоос цаадуул нь яг өөртэй нь түүний тухай ярьж зүрхлэхээр харьцаж байсан.

Тэгээд тэднийхээ яриаг сонсоно.

Биеэ тоосон, эзэрхий хүүхэн бүхнийг захирах санаатай байтал түүнийг захирч болохгүй болж таарч, мань хүн өөрөө захирах ёстой юм чинь. мань хүн ИЙГ туж эсэргүүцээд байсан, дуугүй байлаа ч гэсэн түүний үг болгоны эсрэг байгааг нь Тэрээр даанч харалгүй яахав. Хүүхэн шүү! Гэргий байж чаддаггүй юм бол үгүйдээн эх хүн байх л даа. Хүүхдүүдээ хэнд хаяж байна вэ? Василий яахав, эр юм чинь өсч өндийнө, харин зургаахан настай Светланаг, зургаагаар охиныг хэн рүү шидэж байна аа? түүний нуруунд үүрүүлсэн болж байна уу?

Сурлага муу, хортой сахилгагүйтэж байна гэж сургуулийнх нь багш нар Василийн талаар гомдол мэдүүлсэн, учрыг нь олох гэж мань хүн өөрөө сургууль дээр нь очсон, ӨӨРӨӨ очдог нь Тэрээр эцэг хүнийхээ үүргийг ердийн зөвлөлтийн хүний адил биелүүлж байгааг ард түмэн мэдэж байг гэснийх. Гэтэл энэ үүргийг чинь уул нь эх нь биелүүлэх ёстой шүү дээ. Үүрэгнээсээ зайлсхийлээ, з у г а т л а а, өөрөөс нь өсөө авлаа, яасан гэж тэр вэ? Театрт цуг яваагүй гэж тэр үү? Ажилтай, завгүй байсан, тэгээд л яваагүй хэрэг.

түүнийг яаж хайрлаж явлаа даа. Бүр жаахан, гуравхан настай охин байхад нь анх харсан өдрөө санаж яваа. Уфагаас оргосныхоо дараа мань хүн Аллилуевын ирсэн, харин тэр охиныг огт анзаараагүй, тэгсэн хэрнээ Тифлисийн тэр нэг өдрийг санасан хэвээр... Анзаараагүй хэрнээ мартаагүй.

Анзаарахын хувьд гэвэл хожим 1912 онд Сила Тодриатай хамт Петербургийн Сампсониевын өргөн чөлөөн дэх Аллилуевын гэрт ирэхдээ л сая анзаарсан. Нүдэн баримжаагаар арван гуравтай гэж хэлж болохоор арван нэгтэй хөөрхөн охиныг мань хүн тэгэхэд харжээ. Арван гурван нас бол гүржийн заншлаар бэрийн нас. Хэрсүү, бүрэг, эгч Анягаа бодвол дуу цөөнтэй охин.

Тэрээр Аллилуевынхаар орж гарах нь олширч, заримдаа тэднийд хонохдоо гал зуухны арын

жижигхэн өрөөнд нарийхан төмөр орон дээр унтана.

Хоёрдугаар сард мацаг барих тосны баярын үеэр тэд нар чаргаар гулгацгаана. Тэдний гулгадаг жаахан финн чаргыг тэр үед “вейках” гэдэг байсан бөгөөд олон янзын туузан чимэг, хангир жингэр хийсэн хонхтой, түүнийг дэлийг нь сүлжсэн намхан морьдод хөллөчихнө. Хунгарласан цасан дээгүүр оволзуулан гарахад нас бие гүйцсэн Аня чарлан маяглаж байхад дугуй үстэй малгайтай, үстэй дээлтэй, тэгшхэн хөлдөө түрийтэй шаахай өшиглөсөн дуу цөөнтэй, амгалан, хөөрхөн охин Надя чимээгүй л сууж байна.

Тэгээд эцэст нь 1917 оны хавар, гуравдугаар сар... мань хүн Петроградад ирээд шууд Выборгын тийшээ очтол Аллилуевынх тэндээс нүүчихсэн, Торнтоны үйлдвэрийн хавьд аж төрөх болсон байжээ. Тийшээ уурын тэргээр явахаас өөр аргагүй. Ганцхан Аня гэртээ байж. Надя хөгжмийн хичээлдээ явчихсан ажээ.

Тэгэхэд мань хүн хэнийг хүлээж байсан бэ?

Мэдээж хоёр хөгшнийг хүлээж байсан, тэднийд л ирсэн юм чинь. Харин үнэн хэрэгтээ бол нөгөө охиныг хэзээ ирэх бол гэж хүлээж байжээ. Аллилуев өөрөө ирж, тэр хоёр гал зууханд халуун тогооноос цайлж суутал үүдэнд нь гэнэтхэн Надя гараад ирэх нь тэр.

Яг дээр үеийнх шигээ малгай, дээлтэй, гэхдээ хэдийн арван зургаа хүрсэн чацархаг, гоолиг сайхан бүсгүй. Аавтайгаа төстэй, Сергей Яковлевичийн эмээ нь цыган байсан юм, Надя ч бас дүрлэгэр хар нүдтэй, боровтор царайтай, яралзсан цагаан шүдтэй.

Тэрээр үстэй дээлээ тайлж, гимназийнхаа дүрэмт хувцастай чигээрээ хоол унд, ширээ зэхэлцэх зуур түүнийг зангидсан хөмсөг доогуураа гэнэ гэнэхэн харна. Ширээ тойрон суухын цагт өрнөсөн яриаг аанай л үг дуугүй, анхааралтай, үнэн санаанаасаа сонсож байхдаа түүний яриаг л сонсож суусан. Тийм учраас мань хүн Сергей Яковлевичийн улс төрийн цуурхлыг дэмжилгүй, цөллөгийн тухай, Сибирийн тухай, загасчлах тухай, Свердловтой хамт сууж байхдаа гэрийн ажлаас зайлсхийхийн тулд өөрийнхөө ээлжнээс гадуур шуудан эргэх гэж яаж зүтгэдэг байсан тухай энэ тэрээ хөөрөн яриа дэлгэв. Хөгжилтэйхэн хөөрсөн дөө.

Тэгэхэд түүнд хоолны өрөөнд аргүй буйдан дээр ор засч өгсөн, яг тэнд нь өөр нэг буйдан дээр Аллилуев унтсан. Нимгэхэн хананы цаана Ольга Евгеньевна, бас Аня, Надя хоёр цуг унтацгаасан. Тэр хоёрын инээд, шивнээ яриа түүнд сонсогдож байсан. Дараа нь Аллилуев өвгөн хана руу гараа зангидан түншилж,

-Чимээгээ аядацгаа!.. Унтах цаг болчихоод байна гэж сануулсан.

Тэгэхээр нь мань хүн,

-Эднийг битгий оролд, залуучууд инээлдэж байг л дээ, Сергей гэж чанга хэлсэн шиг санагдана.

Тэрээр зориуд “залуучууд” гэж хэлсэн. Эцгийнх нь андын хувьд ахмад хүний байртай байгаа нь тэр, гэхдээ өөрөө Аллилуеваас арван гурав дүү, тэр үед мань хүн 38-тай, харин Аллилуев

бол хэдийн тавь гарчихсан байсан юм. Энэхүү насны ялгааг Надя өөрөө анзаараасай, эцэгтэй нь үе тэнгийнхэн шиг байж зохихгүй гэдгийг мэдрээсэй, тэгээд “Та юуных нь өвгөн байх вэ! Та залуу байна!” гэж бодоосой гэж мань хүн хүссэн билээ. Тэгж хэлэх биш, зөвхөн бодоход л болоо.

Тэгж хэлсэн бол тусгүй л дээ, ая тал засч саймширч байгаа юм шиг л сонсдоно. Мулгуу Аня бол тэгж хэлж чадах л даа, харин Надя бол чадах ч үгүй, тэгж хэлээ ч үгүй. Тэгэхэд мань эр түүнийг үнэлж ухаантай бүсгүй гэж дүгнэсэн. Бас өөрийг нь сонирхох маягтай байгааг харсан. Энэ бол шорон, цөллөгийг туулсан нууц хувьсгалчийг сонирхсон зүгээр нэг сонирхол биш, тийм сонирхол бүх залууст байгаа. түүний сонирхол арай л гойд байсан даа.

Өглөө нь дахиад л цөмөөрөө хамт нөгөө өрөөндөө цай ууцгаав. Надя хэзээ язааны танил шиг өөриймсөг, гэрсэг харагдана. Гаднаас өглөөний сонингууд авчраад нийтийн дунд маягтай ширээн дээр тавьсан ч мань хүн энэ бол ТҮҮНД анхаарал тавьж буйн тэмдэг гэдгийг мэдэрчээ.

Дараа нь, нэг бүтэн сайн өдөр шиг санагдана, тэд нар-мань хүн, Надя, Аня, Федя дөрөв давхар трамвайны дээвэр дээр суугаад явцгааж байсан. Аллилуевынх Невийн харуулаас төв рүү ойртон нүүх санаатай, тэгээд хоёр охиноо хүүтэйгээ хамт шинэ байр хайлгахаар явуулсан нь тэр билээ. Шинэ байранд мань хүн-д ч бас нэг өрөө байлгах тохиролцоотой. Асуудлыг шийдэх үед Тэрээр өөрийг нь битгий мартчихаарай гэж инээж байсан бил үү дээ.

-Намайг мартчихав аа... Надад ч нэг өрөө хөлслөнө шүү... Мартуузай... гэж трамвайнаас буухдаа мань хүн давтан хэлээд хуруугаараа зангажээ.

Тийнхүү хуруугаар зангахад л Надя анх удаа инээмсэглэж билээ. мань эр үүнийг сайн санаж байна.

Чухамхүү тэгэхэд л Надя түүний тоглосон үгэнд биш, чухамхүү ТҮҮН рүү өөрт нь анх удаа инээмсэглэсэн билээ.

Тэд нар 10 дугаар Рождественкийн гудамжны 17а дугаарын байшингийн зургадугаар давхарт сайхан байр хөлсөлж авчээ: Үүд нь сайхан цэлгэр, хоолны том өрөөтэй, тэр нь Аллилуев, Федя хоёрын унтлагын өрөө, Ольга Евгеньевна, Аня, Надя гурвын унтлагын өрөө, тэгээд түүний суух хажуугийн дамждаггүй өрөө.

Ингээд Тэрээр чухамдаа тэдний ам бүлийн хүн болжээ. Надяг бараг өдөр болгон харна. Энэ дуу цөөнтэй, хөөрхөн, учир битүүлэг охин түүний сэтгэлийг татсаар. Бас охин ч түүнд зүгээргүй байгааг мань хүн үзсээр, ойлгосоор... Гэвч тэрбээр Хувьсгалын ажилд шамдаад чөлөө байхгүй, анх удаагаа Хувьсгалын ажилд нууцаар биш, ил байдлаар зүтгэж байна, хувьсгал болж байгааг хоёр нүдээрээ харж байна, түүнд өөрөө оролцож “Правда” сонинд ажиллаж байна, редакцийнхаа газар хонох нь элбэг, амьдрал босч суухын завгүй буцалж байна.

Тэмцэл явж байгаа болохоор түүний хувь заяа, тэдний хөдөлгөөний хувь заяанаас авахуулаад бүх юм тодорхой бус. Ийм үед Тэрээр охины амьдралыг өөрийнхөө буцалж бургилсан,

тогтворгүй амьдралтай холбож чадах уу?

Нөгөөтэйгүүр энэ охин юунд хөтлөгдөнө вэ? Тэрээр түүнээс хорин хоёр ах. Кавказад бол энэ юу ч биш, илүү ахимаг хүмүүс залуухан хүүхэн авахыг алийг тэр гэх вэ. Бас түүний насан дээр ахмад харчуулыг шохоорхох явдал ч элбэг.

Гэтэл Надя эцэг шигээ хувьсгалч идеалист үзэлтэй, тэгэхээр түүнийг дэндүү адбиш сэтгэлээр харж байгаа биш биз? Гэр бүл гэдэг чинь адбиш жаргалан биш, ёстой биш. Тэрээр нэг удаа үүнийг үзчихсэн. Юу болсон билээ? Тифлист нэг хүү торниж байгаа, түүнийг мань хүн бараг үзээгүй, мэдэхийн хувьд бол огт мэдэхгүй. Эхнэртэй байсан, түүний хувьд бас л элэг буруутай хүн. Хувьсгалч хүнд гэр бүл бол хар дараа... Тэгэх тусмаа одоо Хувьсгал болж байхад бүр ч дараа. Нөгөө талаас Хувьсгал бол хуримлаж байдаг цаг биш. түүний бүх нөхөд нь гэр бүлтэй. Авгай нар нь тэдний намын нөхөд. Хүүхнүүд биш... Огт биш!

Надя бол тэдний өрөөсөн биш. Энэ бол шал өөр. Гэтэл бас цаг үе ч тэс ондоон... Намын дотор байр сууриа багатгаж авах хэрэгтэй. Цөллөгнөөс Петроградад эргэж ирсэн анхных нь өдөр, гуравдугаар сарын 12, (Тэд нар гурвуулаа ирсэн: мань хүн, Каменев, Муранов гурав) буюу яг тэр өдөр нь Төв Хорооны Оросын товчоо дараах шийдвэрийг гаргасан: Мурановыг товчоонд оруулах, түүнийг, Сталиныг “хувийн зарим нэг чанарыг нь харгалзан” зөвхөн зөвлөх эрхтэй оруулах, Каменевыг “Правда”-гийн ажилтнаар авч өгүүллүүдийг нь нийтлэж байх, гэхдээ 1914 онд шүүх дээр журамгүй зан гаргасныг бодолцон нэрийг нь гаргахгүй байх.

Мөн тэнэг шийдвэр шүү! Шляпников гэж нэг муу дүйрэн өөрийгөө Төв Хорооны Оросын товчооны удирдагч гээд бодчихож. Уул нь мань ЭР, Каменев хоёр чинь Төв Хорооны гишүүний хувьд Шляпниковыг бодвол хамаагүй ахмад гишүүд шүү дээ. Ямар үндэслэлээр тийм шийдвэр гаргаж байна?

Тэрээр маргааш нь уг шийдвэрийг тулгаж засуулсан. түүнийг товчооны бүрэлдэхүүнд таслах эрхтэй оруулсны зэрэгцээ Ольминский, Еремеев, Калинин, Мария Ильинична Ульянова нарын хамт “Правда”-гийн редакцийн бүрэлдэхүүнд оруулжээ. Ийм бүрэлдэхүүнтэй “Правда”-д мань хүн эзэн болон хувирч, тэгээд гурав хоногийн дараа буюу гуравдугаар сарын 15-нд редакцийн шинэ бүрэлдэхүүнийг зарлажээ: Сталин, Каменев, Муранов...

Мэдээж Ольминский эсэргүүцээ л дээ, хөөрхий. Гэвч тэглээ гээд ямар нэмэр байх вэ? Тэрээр гуравдугаар сарын 12-нд Петроградад ирээд, дөнгөж 15-ны өдөр гэхэд эндхийн жинхэнэ удирдагч хэн болохыг тэдэнд үзүүлж өгчээ.

Тэр үед “Правда” болон дараа нь түүний толгойлсон “Рабочий путь” сонины байр суурь зөв байсан уу, буруу байсан уу, т э р ү е д бусад социалист намын тухай, Лениний “Дөрөвдүгээр сарын сэдвүүд”-ийн тухайд, Зиновьев, Каменев хоёрын “урвалтын” тухайд түүний байр суурь зөв байсан уу, буруу байсан уу, энэ бүхэн о д о о ямар ч ач холбогдол байхгүй, харин т э р ү е д э э бол ач холбогдолтой байсан. Тэрээр намд удирдах үүрэгтэй болохын төлөө тэмцэлд их баширласан, тухайн нөхцөлд тэгэхээс ч өөр зам байгаагүй, тэр нь үр дүнгээ өгч, мань хүн Октябрийн хувьсгалын үеэр намын нэг удирдагч, Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, цаашлан Зөвлөлтийн анхны засгийн газрын гишүүн болсон.

Гэхдээ тэр үед тэмцэл ч байсан, сонин ч байсан, баширлалт ч байсан, мань хүн бусад хүн шиг цуглаан хэсч гүйгээгүй, элдэв уран цэцэн үг урсгаагүй, мань хүн ажиллаж байсан. Тэгээд бүх юм тодорхой болсон хойно Тэрээр Ленинтэй эцсийг нь хүртэл цуг явсан, тийм учраас одоо түүнийг хэн ч, юугаар ч буруутгаж чадахгүй.

Тэр өдрүүдэд түүнд амин хувийн ажлаа гэх сөхөө даанч байгаагүй.

Тэрээр Рождественка гудамжны байранд хаа нэгхэн очихдоо л Надягийн барааг харна, тэр охин түүнийг догдлуулдаг ч гэсэн юун түүнтэй мантай. Энэ тухай бодох цаг ч түүнд байгаагүй.

түүний орноос Надя бодчихжээ.

Зургаан сарын дурсгалт нэгэн өдөр. Тэрээр редакцийнхаа умгар өрөөнд юу ч билээ бичээд л, амьтан хүн орж гараад л байсан цаг. хэн орж, хэн гарч байгааг мань хүн огт анхаарахгүй, гагцхүү хаалга савах бүрт цухалдан суусан, хаалганы дуунд ер нь хэзээний дургүй л дээ. Гэтэл энд тэвчихээс өөр арга байхгүй, мань хүн ч тэвчээд л байж.

Харин хаалга онгойход ганцхан удаа тийшээ харжээ. Яагаад харсан юм бол?

Үүдэнд нь Надя зогсож байх нь тэр. түүнийг эхлээд харж. Дараа нь Аняг ч харж.

Ойр зуурхны юм ярьцгааж. Яагаад ийм удаан үзэгдэхгүй байна... Өрөө чинь хүлээж байгаа... Энэ бүхэн чухамдаа хов хоосон үг. Надя түүн дээр ирсэн нь л гол зүйл. Тэгэхээр өөрийг нь хармаар байсан хэрэг.

-Та ойрд ирсэнгүй. Бид таны тухай санаа зовцгоох л юм гэж Аня өгүүлжээ.

Юундаа санаа зовох сон билээ? Санаа зовох шалтгаан алга. Тэдний гэрт өглөө болгон сонин очиж байгаа, түүний өгүүллүүдийг уншиж байгаа, амьд мэнд гэдгийг нь мэднэ шүү дээ.

Надя түүнийг харах гэж л иржээ. Санасан байх нь. За энэ л чухал, энэ л гол зүйл.

Яг түүнийг хармагцаа, үүдэнд зогсож байгаа чацархуу, гоолиг, хөөрхөн охиныг хармагцаа энэ бүсгүй өөрийнх нь эхнэр болно хэмээн Тэрээр шийдсэн болой.

Тэрээр энэ өдрөөс эхлэн Рождественка гудамжны гэртээ ойрхон ойрхон ирэх болжээ.

Аллилуевынхан түүнийг харж хандан, хооллож ундална, тэр ч байтугай костюм авч өгчээ. Аня гэр барааны ажилтай бүхнээс илүү ноцолдовч эдний хамгийн бага Надя л айлын жинхэнэ эзэгтэй болж байлаа.

Ольга Евгеньевна, Аня хоёр миегнэлдэн, ярихдаа хүртэл гэрээр нэг хашгичин түүнд садаа хийнэ. Тэгэхэд Надя хормогчтой, шүүр барьчихсан, хий миегнэлгүй, худлаа дуу шуу болохгүй байраа гялалзтал цэвэрлэж, бүх юмаа байр байранд нь тавилана. Гэр орноо эмх цэгцтэй, цэвэр цэмцгэр байлгах дуртай. Жинхэнэ эзэгтэй!

Оройн цагаар бага гарын төгөлдөр хуураа тоглоно, өөртөө л тоглоно, түүнийг ирэхээр тоглохоо больчихно.

-Яагаад тоглохгүй байна, яагаад больчихов гэж мань хүнийг асуух тоолонд,

-Та амар, танд саад болоод яахав гэж хариулна.

Надя бүр гимназид суралцаж байх үеэсээ большевик нэр авсан, ангидаа Керенскийг шоолон шүүмжилсэн, хаант засгийн хохирсон гэх хэдэн түшмэлд зориулж мөнгө хандивлахаас татгалзсан гэх. Тэрээр энэ тухай өөрөөс нь бус Ольга Евгеньевнагаас дуулсан билээ.

Зарим орой гэрээрээ ширээ тойрон сууцгаах нь бий. мань хүн Надяг төгөлдөр хуураа дарж өгөхийг хүсэхэд цаадах нь татгалзана, тэгэхээр нь Чеховын зохиолоос уншиж өгөхийг хүснэ, Тэрээр Чеховын зохиолд дуртай, түүнээс Надягаар уншуулах бас дуртай. Надя сайхан уншина.

Аня бас уншина, гэхдээ муу уншина, инээдээ барьж чадахгүй, уншлагаа таслалчаа элэг нь хөшөөд унаад өгнө, юу ч ойлгохын арга байхгүй... Надя уншихдаа өөрөө хэзээ ч хөхрөхгүй, харин сонсогчид нь инээвэл түр азнаж байгаад үргэлжлүүлээд уншина, “Хамелеон”, “Бага дарга Пришибеев” энэ тэрийг уншина, бас “Хонгор найз”-ыг унших боловч нэг их дуртай бус байх шиг ТҮҮНД санагдана.

Заримдаа түүн дээр найз охид нь ирнэ. мань хүнд тэдний цовоо цолгин дуу тодхон сонсоно... Тэгж байснаа францаар яриад эхлэнэ... мань хүнээс л ямар нэг юм нуух гэсэндээ францаар ярьцгааж байна, яг даа, хэмээн Тэрээр хорсон хөмсөг зангидан гарч ирнэ. Гэхдээ Надягийн франц хэл мэддэг, төгөлдөр хуур дардаг, бас хэрсүү, хүлээцтэй төрх энэ тэр нь түүний дурыг булаана.

Тэрээр нэг удаа орон дээрээ хэвтээнэж байгаад,

-Иосиф! гэх дуудлагаар сэржээ.

Тэгээд нүдээ нээв.

Надя үүдэнд нь зогсож байх ажээ... Хиншүү ханхалж буйг мань хүн тэр даруй мэдэрлээ. Хөнжил нь уугиж байна, гаанстайгаа зүүрмэглэчихсэн юм байж.

Надя цонх нээлээ. Өөрөө босон харайж хөнжлөө хуйллаа. Дараа нь Ольга Евгеньевна, Аня хоёр орж ирлээ. Миегнэлдлээ. Дуу алдацгаалаа. Надя түүн рүү инээмсэглэж, гараараа дохьчихоод гараад явчихав.

Тэрээр нэг удаа Камог гэртээ авчирч орхичихоод өөрөө яваад өгсөн санагдана. Камо оройжин юм ярьж тэдний гэрийнхнийг зугацуулжээ. Камогийн ярианд ӨӨРӨӨ ч гарч байгаа гэдгийг Тэрээр мэднэ.

Дөнгөж жилийн дараа, арваннайман онд тэр Надятай гэрлэжээ. Тэгээд тэр даруй Царьцин руу авч одсон. Гэвч хожим Москвад буцааж авчраад түүнээс хойш ийш тийш явахдаа дагуулж явахаа больжээ.

Хэдий үеэс тэр хоёр толхилцох болсон бэ?.. Тэрээр яг тодорхой хэлж чадахгүй.

Светланаг төрсний яг дараачаас л байх...

Тэгэхэд Надя Вася, улаан нялзрай Светлана хоёрыг аваад, хэзээ ч эргэж ирэхгүй гэж зарлачихаад Ленинград руу, эцэг эх рүүгээ гэнэтхэн яваад өгсөн. Өөрийг нь адайр бүдүүлэг гэж нэрлэсэн, бас ичих нүүргүй мугуйд гэж нэрлэсэн. Тэрээр ингэж муулсан хэнийг ч уучлахгүй байсан, харин түүнийг уучилсан: Улсын ярих нь эмэгтэй хүн амаржсаныхаа дараа их уцаар болдог, аливаа хүүхэнд байдаг голын хий айхтар хөөрдөг юм байж.

Тэрээр авгайгаа уучилж, Ленинград руу утасдсан, эргэж ирэхийг гуйсан, бүр араас нь өөрөө очиж авчрахыг завдсан. Хүүхэн хариуд нь “Чи ирвэл улсад дэндүү гарлагатай явдал болно” гэж тохуурхах маяг гаргасан. Тэгээд өөрөө буцаад ирсэн.

Тэр юу хэлэх гээд юу хэлж байна аа? “Чи ирвэл улсад дэндүү гарлагатай явдал болно”. Тэрхэн үедээ мань хүн үүнийг авгайнхаа ердийн тохуурхал, бүсгүй хүний ердийн дамшиглал гэж бодсон. Одоо бол өөрөөр, жинхэнэ утгаар нь ойлгож байгаа. Арван дөрөвдүгээр хурлын дараа, зиновьевчуудыг бутниргэсний дараа, Ленинградын удирдлагыг сольсны дараа хэдхэн сарын хойно мань хүн тийшээ очих нь хэнд ч хэрэггүй бөгөөд аягүй бол буруугаар тайлбарлаж ч мэднэ.

Киров л авгайг нь ятгаж байж буцаасан, Киров л ӨӨРИЙГ нь Ленинградад очуулахыг хүсээгүй, бүр түрүүн бас дургүй байсан юм. Надя тэр хоёр тэнд л их дотносох болсон.

Надя хожим үхлийнхээ өмнөхөн, академиа төгсөнгүүтээ Харьков руу, Реденсийнхэн рүү очно, тэнд ажилд орно гэж өөрт нь зарлах мэт сонгосон.

Асрагчтай ярьсан юмыг нь түүнд ховлосон. “Бүх юмнаас залхаж гүйцлээ, бүх юм улиг болчихлоо, баярлах юм даанч алга” гэж асрагчид ярьсан байгаа юм даа. “Даанч алга” гэж юу гэсэн үг вэ?! Хүүхдүүд маань юу вэ?

Тэгэхээс тэгэх гэж бүх юмыг түүний эсрэг хийж байсан.

мань хүн сүрчгийг ад үздэг, эмэгтэй хүнээс зөвхөн цэвэрхэн, шинэхэн үнэр л сэнгэнэж байх ёстой гэж үздэгийг нь Надя мэднэ. Тэгсэн мөртлөө сүрчиг түрхэнэ, зориуд түрхэнэ, зүгээр ч үгүй Павел гэж ах шуу юмныхаа авчирч өгдөг гадаадын сүрчиг түрхэнэ, тэгэхээс тэгэх гэж гадаадын хувцас өмсөнө. түүнийг нь нөгөө л Павел бас нөгөө эрхэм хайрт Сванизегийнхэн авчирч өгнө. Академи дээрээ зөвлөлтийн жирийн хүмүүсийн дунд гадаадын сүрчиг ханхлуулаад сууж байсан. түүний эхнэр шүү дээ... Ямар вэ дээ?!

Павел түүнд яах гэж гар буу бэлэглэв? Эмэгтэй хүнд гар бууны хэрэг юу байна? Эмэгтэй хүнд гар буу бэлэглэх ухаан хэний толгойд орох вэ?! Павел түүнийг алуулах гэж дүүгээ алсуурхан бэлтгэж байсан юм биш биз? Хэрэг явдал болсны дараачаар мань хүн түүний Кремльд нэвтрэх үнэмлэхийг хурааж авахыг тушаасан. Багадуулжээ, багадуулж! Тэрээр Павелийн тухай шазуур зуун бодов. түүнийг хатуу шийтгэх хэрэгтэй. Мэдэж аваг!

Тэрээр одоо дахиж гэрлэхгүй.

Ард түмэн түүнийг ойлгоно. Хайрт эхнэрээ алдчихаад өөр авгай авахыг хүсэхгүй байна гэж ард түмэн ойлгоно. Сайн эцэг учраас хүүхдүүдээ хойт эхтэй болгохыг хүсэхгүй байна гэж ард түмэн ойлгоно. Өөрөө ч бас хүүхдүүдээ хойт эхтэй болгохыг хүсэхгүй байгаа. Авгай авбал шинэ бэрхшээл, шинэ хэрүүл уруул, шинэ хамаатан бий болно, гэтэл нөгөө шинэ хамаатнууд нь ямар хүмүүс байх бол? түүний энгүүн хээгүй байдлыг ард түмэн хичнээн талархан үнэлдэг билээ, одоо ганцаардал нь тэр энгүүн хээгүй байдал дээр нь их чимэг нэмнэ. түүнийг харж хандах амьтан даанч алга гээд л.

Нөгөөтэйгүүр түүний тухай хов жив байхгүй, энэ талаар холбогдох байгууллагынхан түүнийг хуурч мэхлэхгүй байгаа, энэ тухайд мань хүн хатуу шаардлага тавин, хатуу цээрлүүлж байгаа. Тэрээр хов жив гарах шалтаг өгдөггүй.

Тэрээр нийтийн өмнө үг хэлэх нь ховорхон, үйлдвэр заводуур яваад байхгүй, хурал цуглаан гэж дүрэмдэхгүй, зөвхөн онцгой тохиолдлоор л хэлэх юмаа хэлнэ. Их хурал, бүгд хурал дээр үг хэлэх, хэвлэлээр товчхон мэндчилгээ дэвшүүлэх гэхчилэн. түүний үг хэлэх болгон дорвитой үйл явдал болох ёстой, үг болгон нь жинтэй байх ёстой. Энэ тухайд Пушкин зүйтэй хэлсэн шүү:

Амаа татаж бай, хаантны дуу хоолой

Агаарт хий хоосон замхрах ёсгүй.

Аравнайт хонхны зар мэт тэр хоолой

Аугаа баяр, эсвэл их уйг л айлдах учиртай.

Мөн хэлж байгаа юм шүү.

Пушкиний таалал төгссөний зуун жилийн ойн бэлтгэл хэрхэн явж байгааг үзэж шалгах хэрэгтэй. Пушкинээс авамгүй юм, мэдээж бас бий л дээ, гэхдээ тэр авамгүй юмыг тэр үеийн хаан Нэгдүгээр Николай, түүний тойрон хүрээлэгчдийн эсрэг чиглүүлэх хэрэгтэй. Ингэхийн зэрэгцээ бидэнд хэрэгтэй ашигтай зүйлийг товойлгон тавьж байвал зохино. “Зэс морьт”, “Полтава”, “Их Петрийн негр”... гэхчилэн Петр хааныг тэр л өргөмжлөн дуулсан шүү дээ. Үнэхээр шаардлага гарсан цагт Пушкин тухайн үеийнхээ засгийг ч магтан дуулж, гадаад бодлогыг нь ч хамгаалж байжээ.

түүний эрин үед Пушкиний зиндааны яруу найрагч байхгүй нь даанч тоогүй.

Ингэхэд тоогүй гэх юу байх вэ дээ? Харин ч болвоос энэ чинь зүй тогтолтой хэрэг: аугаа их захирагчдын зэргэмцээ аугаа их найрагчид байдаггүй. Александр Македонский, Чингис хаан, Наполеон, Догшин Иван, Их Петр энэ тэрийн үед ямар ямар их найрагч байсан билээ? Нөгөө

талаас, Гомер, Гёте, Шекспир, Пушкин, Толстой энэ тэр ямар хаадын үед байсан билээ? Тэр хаадыг хэн санаж байна вэ? Аугаа их найрагч ард түмний оюун санааны тэргүүний дүрд тодрохыг эрмэлздэг. Аугаа их захирагч бол өөрөө ард түмний оюун санааны тэргүүн, тэгэхээр түүний хажууд оюун санааны өөр ямар ч тэргүүн байж болохгүй.

Энэ бүхэн тийм нь тийм, гэтэл... Санаа бодол сарниад байна. Тусгүй шүү. Бодлоо төвлөрүүлж чаддаг байх хэрэгтэй... Тийм ээ, Тэрээр одоо дахиад нэгэнт гэрлэхгүй.

Сталины анхны эхнэр Екатерина Семеновна Сванизегийн дүү ахмад большевик Александр Семенович (Алёша) Сванизег 1937 онд баривчлаад таван жилийн дараа 1942 онд буудан алжээ.

Буудан алахын өмнө, хэрэв тэр нөхөр Сталинаас уучлалт гуйвал Сталин өршөөл үзүүлнэ гэж түүнд хэлсэнд,

-Би юу гуйх ёстой юм бэ? Би ямар ч гэмт хэрэг өдүүлээгүй юм чинь гэж Сванизе хариулсан гэдэг.

Тэгээд түүнийг буудан хороожээ.

Энэ тухай нөхөр Сталинд илтгэсэнд, Тэрээр,

-Үгүй ер, их омогтой эр байх нь, өршөөл гуйхын оронд үхнэ гэнэ ээ хэмээжээ.

Мөн тэгэхэд, 1942 онд Казахстаны хориход түүний эхнэр Мария Анисимовна амь үргэджээ.

Тэр хоёрын хүү Жоник (Иван Александрович) эрүүгийн ялтангуудтай цуг шоронд сууж байгаад дөнгөж 1956 онд суллагджээ.

Сталины анхны эхнэр Екатеринагийн эмэгтэй дүү Марико 1937 онд баривчлагдаад төдөлгүй шоронд амь үрэгджээ.

Сталины хоёрдахь эхнэр Надежда Сергеевна Аллилуевагийн эгч Анна Сергеевна Аллилуеваг 1948 онд баривчилж арван жилээр хорих ял оноожээ. Тэрээр Владимирын шоронгийн ганцаар хорих өрөөнд сууж байгаад Сталиныг нас барсны дараа суллагджээ. түүний нөхөр Станислав Францевич Реденсийг 1938 онд буудан алжээ.

Сталины эхнэр Надеждагийн ах Павел хуягт танкийн хэрэг эрх-лэх газар ажиллаж байхдаа гэм буруугүй хэлмэгдсэн ажилтнуудыг хамгаалах гэж оролдсоны улмаас Сталин түүнийг хүлээж авахаа больжээ. Павел 1938 онд 44 насандаа гэнэт нас баржээ.

түүний эхнэр Евгения Александровна Аллилуеваг 1947 оны арван-хоёрдугаар сарын 10-нд баривчилж, арван жилээр хорих ял оноожээ. Евгения Александровна 1954 оны дөрөвдүгээр сарын 2-нд суллагдсаны дараа Москвад гэртээ ирээд хүүдээ, “Ямар ч атугай манай хамаатан биднийг суллалаа” гэж хэлж байжээ. Сталин нас бараад жил болсныг тэр мэдэхгүй байсан байна.

Павел, Евгения хоёрын охин Кира Павловна Аллилуеваг 1948 онд баривчлаад Сталиныг нас барснаас хойш суллажээ.

Сталины анхны эхнэрээс гарсан хүү Яков 1941 оны зун германы фашистуудад олзлогдож, эрэлхэг зоригтой байж байгаад 1943 онд учир нь тогтоогдоогүй нөхцөлд амь үрэгджээ.

түүний эхнэр Юлияг 1941 оны намар Москвад баривчлаад Яковыг амь үрэгдсэний дараахан суллажээ.

Ленагийн хөл хүндэрснийг гэрийнхнээс нь хамгийн түрүүнд Ашхен Степановна анзаарчээ.

Оройн хоолны дараа бусад нь өрөө өрөө рүүгээ явмагц ээж нь Ленаг авч үлдэв.

-Байзна, чамтай юм яримаар байна...

Тэр хоёр ширээний ард өөд өөдөөсөө харан сууцгаав.

-Леночка, би андуураагүй биз, чи жирэмслээ юү?

-Тийм.

-Тэгвэл чамд нөхөр байх нь ээ?

-Надад нөхөр байхгүй.

-Уучлаарай... Тэгвэл хүүхдийн эцэг хэн юм бэ?

-Би нэрийг нь хэлмээргүй байна.

Ашхен Степановна дал мөрөө хавчив.

-Бас чамаас нэг юм гуйя. Аавыг энэ тухай надаас бас битгий асуугаарай гэж түүнд хэлж өгөхгүй юу гэж Лена нэмж өгүүлэв.

Иван Григорьевич авгайнхаа ярьсныг чимээгүй сонсож, бодолхийлснээ,

-Энэ ч нөгөө нэг нохойн гөлөг байх аа гэв.

-Лена тэгэхэд түүнээс харьцаагаа тасласан шүү дээ.

-түүнээс чинь хойш тэр хоёр уулзаад л байсан. Ленаг надтай уулз гэж хэлээрэй.

-Иван, цаадах чинь чамтай ярихаасаа айгаад байна лээ, чамайг юу ч битгий асуугаарай гэж надаар хэлүүлсэн.

-Би юун ч тухай асуухгүй, гэхдээ надтай уулзаг.

-Чи зөөлөн харьцаарай. За юу?

-За.

Ашхен Степановна Ленагийн өрөөнд оров.

-Леночка, чамайг аав чинь дуудаж байна.

-Яах нь вэ?

-Чамтай яримаар байна гэнэ.

-Би чамд бүх юмаа хэлсэн. Нэмж юу ч хэлэхгүй.

-Аав чинь чамаас юу ч шалгаахгүй ээ. Тэгэхгүй гэсэн. Чи оч.

Лена номоо хажуу тийш нь тавиад, босч Иван Григорьевичийн өрөө рүү шийдэмгий алхав.

Эцэг нь буйдан дээр сууж байв. Дэргэдээ суу гэж гараараа дохив.

Лена суулаа.

Иван Григорьевич түүнийг нэлээд харж байснаа инээмсэглэв.

-За, намайг өвөө болгох гээд байна уу?

-Хэрвээ бүтвэл.

-Бүтээх л хэрэгтэй дээ. Ноднингийн явдал давтагдах ёсгүй. Би чамайг өөчилж байгаа юм биш, ноднингийнх чинь төрөлтөнд нөлөөлөх вий л гэж зүгээр эмээж байна. Тийм учраас эмчид үзүүлж, эмчийн хяналтад бай гэж чамаас гуйя. Энэ тухай ээждээ хэлээрэй, эсвэл би хэлэх үү?

-Би өөрөө хэлье, тэгээд эмчид ч очъё.

-Одоо асуудлын ярвигтай хэсэг рүү оръё. Хүүхдийн эцэг хэн болохыг би, мэдээж, сонирхож байна. Чи үүнийг ойлгож байгаа. түүнийг албадаж чамтай суулгах гэсэндээ биш, бас хүүхдийн тэтгэлэг авах гэсэндээ ч биш, түүнгүйгээр хүүхдээ хүн болгоцгоочихно. хэн юм бэ? Нөгөө танай ангийн нөхөр үү... Юра гэдэгсэн бил үү?

Лена хэсэг түгдрэв.

Иван Григорьевич хүлээзнэж харлаа. Лена тэгж тэгж,

-Тийм гэж хариулав.

-Тэр чинь мэдэж байгаа юу?

-Мэднэ.

-Та хоёр гэрлэх гэж байгаа юм уу?

-Үгүй чиш.

-Тэр чинь хүүхдийн эрхээ нэхэмжлэх үү?

-Хэзээ ч үгүй.

-За тэгвэл болох нь тэр, хүүхэд бол хүүхэд, хүн болгоно оо. Харин чи шийдвэрээсээ няцаж болохгүй, цаад этгээдээ өөрөөсөө үүрд таягдан хая.

-Би яг тэгсэн байгаа.

Тэрээр аавдаа үнэнээ хэлж байгаа билээ. Майн баярын дараа Юра дахиад гараад ирсэн. Лена нөгөө амралтын яриаг тэдний эцсийн яриа болж таарна, цаадах нь дахиж үзэгдэхгүй алга болно, утасдана энэ тэр гэдэг нь хоосон манж үг гэж итгэж байсан болохоор түүний үзэгдсэнд гайхжээ.

Амралтнаас Москва руу автобусаар буцаж явахдаа Шарок санаандгүй мэт байдлаар дахиад Викагийн тухай яриаг сэргээсэн аж.

-Ингэхэд хэн чамд тийм алтан хошуу өргөчихөө вэ?

Вика шивэгчин гэдгийг Нина Варягаас дуулсныгаа Ленад ярьсан билээ. Варя нэг тоглоомчинтой суусан, түүнтэйгээ ресторан хэсэх нь элбэг, тэнд л Викатай таардаг, тэгээд л түүнийг шивэгчин гэж тас зүтгэдэг юмсанж.

-хүн ярьсан юм гэж Лена товчхон хариулав.

Хэд хоногийн дараа Юра ажил руу нь утасдаж, шийдвэрээ өөрчилсөн эсэхийг Ленагаас асуужээ. Үр хөндүүлэхийг хэлсэн үү, харьцаагаа тасалсныг хэлсэн үү, алин болох нь ойлгомжгүй байж. Гэвч Тэрээр лавлаж тодруулалгүй,

-Үгүй ээ, би шийдвэрээ өөрчлөөгүй, өөрчлөх ч үгүй гэж хариулжээ.

-Тэгвэл үүрд баяртай.

-Үүрд баяртай, Юра гээд Лена утсаа тавьжээ.

түүний явдал одоо иймэрхүү байгаа билээ.

-Үнэн шүү, аав аа, би яг тэгсэн байгаа гэж Лена давтан хэлэв.

Иван Григорьевич охин нь шийдвэртээ бат итгэлтэй байгаа эсэхийг асуух гэснээ болив. Охин руугаа эгцлэн харахад цаадах нь нүдээ буруулаагүй учраас баярлан санаа амарчээ. Охиныг нь нялхамсуу, нунжгар гэцгээдэг.. Үгүй юм аа! Эцгийн охин, эцгийн цус, эцгийн араншин байна!

Тэрээр охиноо мөрөөр нь тэвэрч өөр рүүгээ болгоход охин нь ч түүн рүү налан, бага байсан шигээ толгойгоо мөрөнд нь наав.

Иван Григорьевичийн хэзээний гэгээ муутай ажлын өрөө бүр харанхуй болжээ. Тэр хоёр, эцэг, нас бие гүйцсэн охин хоёр бие биенээ налсан чигээрээ буйдан дээр суусаар. Ийм мөч

тэдний амьдралд ховорхон байсан даа. Сүүлийн хэдэн жил амссан зовлон бэрхшээлийн хариуд ийм мөч л шагнал болж, түгшүүрийн манан бүрхсэн маргаашийг арай амгалан харах хүч сэлбэдэг билээ.

Хаалганы хонх дуугарлаа.

Иван Григорьевич Ленагийн толгойг үнсэж, хүзүүгээр нь энхрийлэн илж нудчив.

-За, охин минь, овоо сууцгаалаа, ингээд гүйцье, над дээр хүн ирж байна.

Иван босч гэрлээ асаагаад өрөөнөөсөө гарав.

Үүдний өрөөнд Марк Александрович Рязанов зогсож байлаа.

Тэр Төв Хорооны зургадугаар сарын Бүгд хуралд ирсэн юм. Бүгд хурал зургадугаар сарын 7-нд дууссан. 8-нд Оржоникизе дээр орж зөндөөн удаан суужээ. Харин Иван Григорьевич дээр ороогүй, хэдийгээр тэдний харилцаа хөндийрсөн ч нэг газраас утасдаж, орой гэрээр нь түргэхэн ороод гарах зөвшөөрөл хүсчээ. Хөндийрсний наад учир нь Рязанов зээ дүүгийнхээ талаар Сталинд хүсэлт тавиагүй, тэр тухайд нь Иван Григорьевич хачирхаж буйгаа хэлснээс болсон, цаад учир нь бол тэр хоёр Сталинд өөр өөр хандах болсон явдал аж.

Рязанов бэрхшээлтэй байгаа, түүнийг ажлаас нь халж, Кемеровод

барьж буй комбинат руу шилжүүлэх сураг гарсныг Будягин мэднэ. Хачин томилолт. Марк Александрович төмөрлөгийн мэргэжилтэй болохоос уул уурхайнх ч биш, химич ч биш, барилгачин бол бүр биш. Оржоникизе түүнд шинэ томилолтын нь тухай мэдэгдчихээд, шилжүүлж байгаа жинхэнэ шалтгааныг нь хэлээгүй бололтой. мань хүн үүний л төлөө, нарийн учрыг нь Будягинаас лавлах гэж л наашаа ирсэн нь мэдээж. Гэвч Иван Григорьевич өөрөө юу ч мэдэхгүй учраас түүнд туслаж чадахгүй л дээ.

Тэр хоёр дотогшоо орцгоолоо. Марк Александрович зөвшөөрөл хүсээд пиджакаа тайлав. Тэрээр лухагар улаан хүзүүтэй, халзарч яваа намхан бүдүүн эр билээ. Уухилж амьсгаадаад, харцанд нь сэрэмжилж түгшсэн шинж илэрхий.

-За, Марк, амьтны яриагаар бол чи чинь, Кемерово явах гэж байгаа юм уу? гэж Будягин асуулаа. Рязановыг нэрээр нь дуудаж байгаа нь нөхөрсөг харьцаагаа харуулах гэсэн хэрэг. Рязановт өөрийнх нь туслалцаа хэрэгтэй байгааг ойлголгүй яхав.

-Явах гэж байна. Харин яагаад шилжүүлэх болсны шалтгааныг л мэдмээр байна. Гэтэл Григорий Константинович шалтгааныг нэрлэсэнгүй. Намын хүсэл зориг л тийм байна, Кузнецийн сав газрыг өөд нь татах хэрэгтэй. Чамайг одонгоор шагнасан, тэр бол үнэлж байна гэсэн үг гэх мэтийн юм хэлсэн.

Гуравдугаар сарын “Правда” сонинд хүнд аж үйлдвэрийн салбараас Лениний одонгоор шагнагдсан удирдах хүмүүсийн урт жагсаалт нийтлэгдсэн юм. Тэдний дотор Рязанов ч байсан. Жагсаалтыг Оржоникизе өөрөө магнайсан. Будягины нэр харин байгаагүй.

-Ямар учиртайг би ойлгохгүй юм. Ломиназетэй холбоотой юм уу? Ломиназе нэгдүгээр сард амиа хорлосон. Бид хоёр ойр дотно байгаагүй ч, хэзээ ч ам муруйж яваагүй. түүний амиа хорлосон нь надтай ямар ч холбогдолгүй, Иван Григорьевич, та ч сайн мэдэж байгаа. түүнийг мужийн намын хорооны нарийн бичгийн дарга Рындин байн байн дууддаг, бүдүүлэг харилцдаг байсан.

-Чи яаж мэдээв?

-Манай заводынхан бүгдийг нь мэднэ, Иван Григорьевич. Ломиназе Коминтерний нэгэн хуйвалдааныг толгойлсон тухай хэн нэгний мэдүүлгийг түүнд үзүүлсэн юм шиг хүмүүс ярилцдаг юм, өөрөө бол надад тийм юм яриагүй л дээ. Тэгээд Рындин ээлжит удаагаа түүнийг дуудахад нь очиж яваад шууд машин дотроо өөрийгөө буудчихсан, жолооч нь дугуй хагарчихлаа гэж бодоод зогссон гэдэг юм. Харсан чинь Ломиназе хажуулдчихсан, “эм хүн шиг буудлаа” гэж дуугарчээ. Жолоочийнх нь ярьснаар бол тэд нар үүний өмнө зогсож, архи ууж, хүйтэн юм идсэн гэж байгаа, бодвол өрц нь огшсон биз, Ломиназе хөхнөөсөө доош хоёр хуруу хэртэй газар зөв буудсан ч зүрхээ оносонгүй. Тэд нар буцаж ирж, Виссарион Виссарионовичийг эмнэлэгт хэвтүүлж, мэс засал хийсэн, гэвч нойрсуулах эм нь гаралгүй нас барчихсан.

Иван Григорьевич түүний ярьж байгааг бүгдийг нь мэдэх боловч анхааралтай сонслоо. Тэрээр илүү ч юм мэднэ: Чира болон бусад бэртэгчингүүдийн хуурамч мэдүүлгийг Сталины шууд даалгавараар Ломиназед өөрт нь явуулж байсан юм.

-Григорий Константинович талийгаачийг хайрладаг байсан юм чинь их гашуудсаныг би ойлгож байна. Харин би бол энэ хэрэгт өчүүхэн ч гэм байхгүй... Тэр улс төрийн том зүтгэлтэн юм чинь түүнтэй гар нийлж ажиллахад надад хэцүү байсан, би бол жирийн инженер, гэхдээ барилгын ажлыг ямар ч атугай би толгойлж байсан. Хэдий тийм боловч дахин хэлэхэд бидэнд зөрөлдөөн байгаагүй. Нөхөр Сталин Ломиназед яаж ханддагийг би бас мэднэ, гэхдээ би сохроор дагалдаж яваагүй. Бас яасан гээч! Гүржийн заншил ёсоор Виссарион Виссарионовичийг нутагт нь оршуулна гэж би бат итгэж байтал хотын оршуулгын газар нутаглуул гэж тушаал буулгасныг ёсоор болгосон. Гүржүүд гарын үсгээр мөнгө цуглуулж байгаад нэг их гайхуулам юмгүй ч тэрүүхэндээ хөөрхөн хөшөө босгосон, би яаж хориглох билээ? Нөхөр Сталин үүнд дургүйлхсэн юм болов уу?

-Тэр гарын үсэгтэй баримт нь хаана байна? гэж Будягин асуув.

-Санхүүд. Баримт яг ёсоороо байгаа. Сайн дураар цуглуулсан мөнгө. Тэрнээс нь төлбөр хийж завод зарим материал өгсөн, ялихгүй зүйл, гэхдээ яг номын дагуу.

Будягин дуугарсангүй. Рязановг дургүй нь хүрч эхлэв. Хаяагаа манаад л... Айж байх нь. Гарын үсэгтэй баримтыг санхүүдээ хадгалчихаж. Тэр жагсаалтад нэр нь байгаа болгоныг, тэр бүх золгүй гүржүүдийг цаг нь болохоор үгүй хийнэ гэдгийг үнэхээр ойлгохгүй байна гэж үү. Сталин буяны тийм өглөгийг өршөөдөггүй шүү дээ.

-Иван Григорьевич, би тантай зөвлөх гэсэн юм... хэмээн Рязанов итгэл муутайхан эхлэв. - Намайг санамсаргүй шилжүүлээгүйг би ойлголгүй яахав. Гэхдээ шалтгаан нь надад

тодорхойгүй байна. Үйлдвэрлэлийн шалтгаан байхгүй: барилгын явц хугацаанаасаа түрүүлж яваа, төмөрлөгийн чанар дээд зэрэгтэй байгаа, хотыг тохижуулж байна, нэгдүгээр сард трамвай ашиглалтад оруулсан, бичиг үсэг үл мэдэх явдлыг устгасан, өнгөрсөн онд дээд сургууль, техникум, бичиг үсгийн сургуульд нийтдээ гучин хоёр мянган хүн суралцсан, түүнээс арван мянга нь ажлынхаа хажуугаар. Хот соёлын төв болж чадсан, манайд Собинов, Обухов бас Катаев, Гладков, тэр ч байтугай Луи Арагон хүртэл ирсэн. Хоосон газар дээр бүгд л бидний гараар бүтсэн зүйл шүү дээ. Гэтэл яагаад гэнэтхэн халахдаа хүрэв?

-Чамайг халаагүй, одооныхоос чинь дутуугүй хариуцлагатай ажилд шилжүүлж байгаа шүү дээ гэж Иван Григорьевич зөрөв. -Энд чангааж дөнгөлөө, сайн байна, одоо өөр газар чангаа. Манай арга барил тэр.

-Тийм нь ч тийм хэмээн Марк Александрович санал нийлэв.

-Нам намайг хааш нь явуулна, би тэнд ажиллахад бэлэн байна. Гэхдээ Пятаковын комисстой холбогдсон ноднингийн явдлыг санаж байна уу?

-Нөгөө чиний баривчилчихдаг комисс уу? гээд Будягин инээв.

-Би баривчлаагүй шүү дээ, Иван Григорьевич, зүгээр л Оржони-кизетэй ярихаас наана тэднийг завод руу оруулахгүй гэж бодсон юм, гэтэл тэд нар гоморхоод яваад өгсөн... Бид нэг кинотеатр, Осоавиахимийн нэг клуб, пионерийн нэг зуслан, хүүхдийн нэг цэцэрлэг, хүхэрт рашааны ойролцоо нэг сувилалын газар энэ тэр барьсан нь үнэн. Улсын хөрөнгөөр бариагүй, хүмүүс оройн цагаар, амралтынхаа өдрөөр ажилласан, өөрсдийнхөө төлөө, үр хүүхдийнхээ төлөө урам зоригтой ажилласан. Орон сууц, ахуйн барилга барихгүйгээр завод хөгжиж чадахгүй. Энэ явдлыг Сталины өрөөнд авч хэлэлцсэн, Оржоникизе, Ворошилов хоёр байлцсан, өөр хэн ч билээ, Ежов ч билүү дээ, байсан. Нөхөр Сталин бидний үйлдлийг зөв гэж хүлээн зөвшөөрсөн, барилгын ажлыг сайшаасан, бүрэн дүүрэн сайшаасан. Тэгээд Пятаков комисс явуулсныг алдаа, бүдүүлэг алдаа гэж үзсэн. Гэтэл долоо хоногийн өмнө намайг мужийн намын хороон дээр дуудаж, энэ хэргийн талаар бичгээр тайлбар өгөхийг шаардсан. Тэр барилганууд төлөвлөгөөнөөс гадуур ажил, тийм учраас хууль бус гэдгийг хүлээх, бас төвөөс ирүүлсэн комиссыг хэрэг дээрээ баривчилснаа хүлээхийг тус тус шаардсан. Би Сталины өрөөнд болсон зөвлөлгөөний тухай тэдэнд тайлбарлаж, нөхөр Сталин миний үйлдлийг сайшаасныг хэлсэн. Тэд нар: бид танаас Сталины үйлдлийн тухай асуугаагүй, таны үйлдлийн тухай асууж байна, битгий нөхөр Сталины нэрийг бариад бай, өөрийнхөө үйлдлийн өмнөөс ө ө р ө ө хариулах зоригтой бай гэж байна. Би ажилчид ажлын бус цагаар сайн дураараа ажилласныг хэлтэл нэг баргар этгээд “Та албадсан учраас л тэд нар ажиллахгүй юу” гэж залсан. Түүгээр барахгүй, энэ бүх барилга заводад, ажилчдад зайлшгүй хэрэгтэй байсныг би тайлбарлаж эхлэтэл мужийн намын хорооны нарийн бичгийн дарга Рындин “Тэр бүхэн чинь ажилчдад биш, хялбархан алдаршихад чинь таны хувьд л хэрэгтэй байсан” гэж миний үгийг тасласан.

-Тэд нар тэгээд юу гэж шийдсэн бэ дээ?

-Учрыг нь олохыг намын комисст даалгасан. Товчдоо, гишүүний сахилгын хэрэг нээлгээд шилжиж байна, ажил хийснийхээ төлөө тийм л шантай хоцорлоо.

-Чи Сталинтай яривал яасан юм?

Рязанов духайж,

-Тэр намайг хүлээж авсангүй гэв.

-Чи чинь Төв Хорооны орлогч гишүүн шүү дээ, Бүгд хурал дээр чи байсан.

-Бүгд хурал дээр би түүн рүү ойртож чадаагүй юм. хүнд Бүгд хурал боллоо. Енукизе ёстой нүднээс гарчихсан байна лээ. Та шийдвэрийг мэдэж байгаа биз дээ?

Иван Григорьевич БХК(б)Н-ын ТХ-ны Сталины удирдаж хийлгэсэн Бүгд хурлын тогтоол бүхий зургадугаар сарын 8-ны өдрийн “Правда” руу харцаараа дохив.

Сталин хамгийн сайн нөхөртэйгөө, талийгаач авгайнхаа загалмайлсан эцэгтэй, хоёр хүүхдийнхээ, Светлана, Вася хоёрынхоо “Авель ах” гэж хайрладаг хүнтэй, тэдний гэр бүлийг яаж ийж байгаад, үгүйдээн өнгөн дээр нь эв найртай байлгадаг цорын ганц хүнтэйгээ тооцоо хийчих нь энэ.

Юуны төлөө гээч?

Енукизе Бакугийн “Нина” гэдэг хэвлэх үйлдвэрийн тухай товхимолдоо Сталины нэрийг худлаа дурдалгүй яг үнэнийг бичсэний төлөө шүү. Сталин тийм хэвлэх үйлдвэр байсан эсэхийг ч мэдэхгүй.

Тооцоо хийлээ!

Яаж хийсэн гээч!

Хоёр долоо хоногийн дотор “Кремлийн хуйвалдаан”-ыг бий болгож, 78 хүн баривчилжээ. Дээр доор гэлгүй толгой дараалан барьсан: ЗСБНХУ-ын ТГХ-ны нарийн бичгийн дарга нарын газрын ажилтан Больших, Еличанинова хоёр, засгийн газрын номын сангийн ажилтан Нелидова, Перельштейн, Симак нар, Кремлийн Зэвсгийн сангийн ажилтнууд, ялангуяа, Засгийн газрын ордны олон цэвэрлэгч-Жукова, Корчагина, Константинова, Катинская, Мельникова, Мещерякова, Орлова энэ тэр, мужаан Попов, хаалгачин Смольцова, зөөвөрчин Дьячков, манаач Неверов... Энэ цэвэрлэгчид, манаачид, номын санчид, хашаачдын танилуудыг, бас тэдний танилуудыг барьсан, “хуйвалдагчдын” олонхи нь бие биенээ таних ч үгүй байсныг хэлээд яахав. Тэд нараас Киров, Аллилуева хоёрын үхлийн холбогдолтой элдэв ярианы тухай хүчээр мэдүүлэг аваад түүнийгээ хувьсгалын эсэргүү гүтгэлэг, нөхөр Сталины болон бусад удирдагчдын нэрийг гутаах оролдлого гэж ангилаад “Кремлийн хуйвалдаан” гэгчийг зохиожээ.

Үүний төлөөнөө Авель Енукизег Бүгд хурал дээр газар дор ортол нь муулжээ. Тэрээр ЗСБНХУ-ын ТГХ-ны нарийн бичгийн дарга нарын газрын албыг ангийн дайснаар дүүргэсэн болж таарч. Ангийн дайсан этгээдүүдийг ивээлдээ авсан, тэднийхээ жигшүүрт хорт зорилгод ашиглагдсан, харийн хүмүүстэй тогтоосон хэлхээ холбоогоо өөрийнхөө намтай харьцах

харьцаанаас дээгүүр тавьсан. Тэрээр цадигаа алдсан, хэт өөхлөсөн, коммунистын нэр нүүрээ хөсөр хаясан, арчаагүй ихсийн дүртэн, ялзарсан бэртэгчин болохоо харууллаа...

Будягин Рязановыг сайн тогтож харав.

Энэ бүхэн Бүгд хурал дээр яригдсан, энэ бүхнийг Рязанов чихээрээ сонссон, гэвч Будягинд энэ тухай ярьж өгсөнгүй.

Яагаад ийм их болгоомжилж байна? Ахмад большевик Авель Енукизег гэсгээн цээрлүүлэхэд, бичиг үсэг муутай, хөөрхий жирийн хүмүүс, цэвэрлэгч, манаач нарыг гэсгээн цээрлүүлэхэд оролцсондоо ичээ юм болов уу?

Үгүй ээ, ичээгүй. Дасчихсан хүн. Нарийн ширийн тодорхой юм ярья гэхгүй байна, яривал энэ бүхнийг өөрөө юу гэж үзэж буйг хэлэх хэрэгтэй болно, чухам үүнээс л айж байгаа. Энэ 78 хүн шиг ямар ч гэм буруугүй сайн залуу, өөрийнхөө зээ дүү Сашаг ноднин өмөөрө-хөөсөө айж байсан шигээ одоо ч айж байна. Ганц Авель Енукизег цээрлүүлэхийн тулд Сталинд өөр 78 хүний амьдрал шаардагдаж. Ганцхан Авелийг буруутгах юм бол нөгөө товхимолоос нь болж түүнтэй илт тооцоо хийсэн болчихно, харин бөөнд нь бол-энэ яах аргагүй хуйвалдаан, бакугийн явдал энд ямар ч падгүй. Енукизе Кремлийг хариуцдаг хүн, Кремльд дайсан шургалсан байна, тэгэхээр Енукизе зэм авалгүй яахав. Завсарт нь ямар ч гэм буруугүй 78 хүн хохирсон, тэр юу шалих вэ!.. Хүрээ нь тэлэх юм бол бүр олон хүн дахиад хохирно, 78-ийг биш 78 мянгыг устгаж болно гэдгийг түүний түүхэнд халдагч хэнбугай ч болов мэдэх хэрэгтэй. Түүх хүмүүсээс үнэтэй, түүх хүмүүсээс чухал-энэ бол сталинч философи.

Харин Рязанов Бүгд хуралд дээр юу болсныг одоо бодоогүй, тэр талаар санаа зовоогүй, өөрийнхөө хувь заяаны тухайд л санаа зовж байна. Хувь заяаныхаа э р г э л т и й г мэдэрч. Хичнээн сайхан явж байлаа, ямар түргэн дэвшиж явлаа, гэтэл гэнэтхэн-зогс!

Кузбасс руу шилжүүлэхийг бол хачирхах зүйл биш. Гэхдээ шалтгааныг хэлээгүй, намын гишүүний хэрэг үүсгэсэн, Сталин түүнтэй ярилцахыг хүсээгүй... Рязанов нэгмөсөн сүйрэх совин татаагүй ч гэсэн айдас төрчихжээ. Тэр айдас үндэстэй.

Сталин Киров дээр Николаевыг олсон, Куйбышев дээр найдваргүй эмч нарыг олсон, харин Оржоникизе дээр хэнийг ч хайхгүй, Сергогийн бахархдаг бүх хүнийг хүйс тэмтрэнэ. Серго өөрөө олж, өөрөө дэвшүүлж хүмүүжүүлсэн аж ахуйн боловсон хүчнүүдийг Сталин дайсан шиг, хорлон сүйтгэгчид шиг үзэж устгана, тэгэхдээ Сергог тэр ажилдаа албадаж оруулах юм уу, тэдний хорлон сүйтгэх ажиллагааны хариуцлагыг албадан хуваалцуулна.

Оржоникизегийн нэр хүнд маш өндөр байгаа нь мэдээж, гэтэл Троцкий, Зиновьев, Каменев, Бухарин, Рыков, Томский энэ тэрийн нэр хүнд доогуур байсан гэж үү? Тэгэхээр Рязановын явдал энэ төлөвлөгөөний л нэг сэжүүр байх. Сталин төлөвлөгөөгөө их урьдаас боловсруулдаг, нүүдлээ ч бас их холоос эхлэдэг юм чинь. Рязанов өөрт нь бурхан шиг итгэдэг, тиймээс хоромхон зуур няцна, тэгэхээр Рязановын явдал Сталины хувьд сайн нүүдэл гэлтэй.

Иймийн учир Будягин өөрийн бодол, өөрийн мэдэж байгаа зүйлийг Рязановт хэлэхгүйгээр шийдэж зөвхөн,

-Чи тэгээд надаар яалгах гэв? гэж асуув.

Рязанов дал мөрөө хавчив.

-Григорий Константиновичтэй ярьсан боловч юм тодорсонгүй. Үнэнийг хэлэхэд би түүнд, намайг мужийн намын хорооны товчоо дуудаж, гишүүний сахилгын хэрэг нээсэн гэж хэлсэн, гэтэл мань хүн, “Төлөвлөгөөнөөс гадуур барилга баривал юу болдгийг харав уу?” гэж инээсэн, Сталины өрөөнд ярихад ч тэр намайг бас дэмжээгүй юм. Намайг шилжүүлж байгаагийн жинхэнэ шалтгаан юу вэ, гишүүний сахилгын хэрэг нээсний жинхэнэ шалтгаан юу вэ гэдгийг тодруулж хэлж өгөхийг би танаас хүсч байна.

-За, би Григорий Константиновичтэй ярих гээд үзье гэж хэлээд Будягин бослоо.

Рязанов ч босов.

-Чамд хэлснээсээ илүү юм надад хэлнэ гэдэгт би нэг их итгэхгүй байна. Гэхдээ боломж таарвал би ярилцана гэж Будягин нэмж өгүүлэв.

Тэгээд бодолхийлснээ,

-Таны зээ дүү яасан бэ? гэж асуув.

Марк Александрович санаа алдав.

-Цөллөгт байгаа.

-Хаана?

-Сибирьт.

-Сибирь том шүү дээ.

-Ангар хавьд л байгаа.

-Ангар хавьд л байгаа хэмээн Иван Григорьевич доогтой ч гэмээр, харамссан ч гэмээр давтан өгүүлээд, -За энэ шив! Хэрвээ юм олж мэдвэл чамд хэлнэ, мэдэж чадахгүй бол битгий юм санаарай... гэв.

-Тэгье, баярлалаа, Иван Григорьевич.

Тэрээр Иван Григорьевич, Ашхен Степановна хоёртой салах ёс ёслоод гарч одлоо.

Вика Варяд бүх үнэнээ хэлээгүй л дээ. Уран барилгач нөхөр нь үнэхээр их ажилтай, Вика түүнийг үнэхээр ховор хардаг нь үнэн. Үүнтэй эвлэрч болох л доо: нөхөр чинь өдөржин ажилтай, чи өдөржин сул байгаа бол түүнгүйгээр бас жаргалтай амьдарч болно шүү дээ. Харин тэгж амьдрахын тулд мөнгө хэрэгтэй, зүгээр ч үгүй их мөнгө хэрэгтэй, гэтэл Уран барилгач цалингийхаа тэн хагасыг хуучин авгай хүүхдүүддээ өгчихнө. Тэр хүүхдүүд нь амьдралаа өөрснөө аваад явахаар том болчихсоныг яана. Тийм байтлаа Викаг ямар нэг юм эрхлэх хэрэгтэй, аль нэг албанд орох юм уу, эрдэмд оройтно гэж байх биш сургуульд орсон ч болох юм гэхчилэн үйлийн үргүй мунхаг юм ярина. Ажиллах, сурах л дутаж гэнэ дээ! мань хүүхэн э х н э р гэдэг албан ёсны зиндаатай хүн шүү дээ, тэд нарын албан ёсны жигшүүрт тодорхойлолтоор бол г э р и й н э з э г т э й, ямар ч атугай ажиллахгүй байх эрхтэй. Нөхөр нь түүнийг зүгээр л өрөвдөхгүй, гамнахгүй байгаа хэрэг. Чарам хийдэг юм нь ажил, хуучин гэр бүл хоёр... Тэд нартаа мөнгө өгөөд зогсохгүй, ерөөсөө харилцаагаа таслаагүй, авгай, хүүхдээ эргэнэ, гэр бүлийнх нь баяр энэ тэрд оролцоно. Тэр ч байтугай эвийг нь олж байгаад Шинэ жилийг хоёр удаа тэмдэглэчихнэ: арванхоёр хүртэл Викатай, арван хоёроос хойш тэд нартайгаа. “Явж хүүхдүүдээ эргэе, би амлачихсан юм” гэх. Тэнд гэр бүл нь байгаа юм бол энд юу байна?

Өөрийнхөө юмыг ч бүрэн авчраагүй, жижигхэн чемодантай л ирсэн, тэр дотор нь хоёр цамц, хос дотуур өмд, хэдэн мөрөвч байсан. Нөгөө суут хүн чинь тэр! Тэрээр “хамтран хураасан хөрөнгөө” эхнэртэйгээ хуваах нь битгий хэл цөмийг нь орхичихсон. Номын сангаа хүртэл орхичихсон, ном нь ажилд нь хэрэг болно оо доо. түүний жинхэнэ гэр тэр, тэр гэртээ л буцаж таарна, Вика үүнд эргэлздэггүй, бас нэг их харуусдаг ч үгүй, ийм амьдралаар яах вэ дээ. Баяр биш үхээнц домог.

Вика түүнтэй эс маргана. Бүх юм хариугүй нарийхан утсан дээр торж байгаа учраас зөрөлдөж гэмээ нь тэр утас тас үсрэнэ гэдгийг ойлгоно. түүнийг тасдаж болохгүй. Чухамхүү Уран барилгачийн авгай байгаа дээрээ л шинэ амьдрал, шинэ хувь заяагаа зохиох хэрэгтэй. түүнийг ө ө р х ү н олж авах ёсгүй, харин өөрөө ө ө р х ү н и й төлөөнөө одооныхоо дээгүүр зиндаа, гэр бүлийн аз жаргалтай амьдралаа золионд гаргана. Хайр сэтгэлийн төлөө юуг эс хийдэг билээ!.. Тэгж чадваас түүний шинэ гэрлэлт үйл явдал болно, гэхдээ тэрхүү шинэ хүнд нь юуны өмнө үйл явдал болно.

Дахиад л нисэгчийн тухай бодол орж ирэв. Гэвч тэд хаана байна, хаагуур тэднийг хайх вэ? Энэ бол зөгнөл. Нэмэрт нь Вика гэрээс бараг гардаггүй юм чинь.

Марасевичийнх урьдын адил хөл ихтэй, зан сайтай айл хэвээрээ. Москвагийн алдартнууд урьдын адил орж гарсаар. Хөгжмийн зохиолч ямар бол? Зураач? Үгүй ээ, тэдний байр суурь дэндүү тогтворгүй.

Ах нь хөгжим, театр, уран зураг, утга зохиол гээд бүх чиглэлээр бичдэг учир тэд нарыг толгой дараалан бутниргэнэ. “Правда” сонинд зохиолч Панферов Горькийг чимхсэн. Горький коммунист зохиолчдыг шүүмжилдэг учраас тэгж чимхсэн нь зөв гэж Вадим ярина. Гэтэл яг тэр нүүрэнд Горькийн Чеховт бичсэн хэвлэгдэж байгаагүй захидлыг нийтэлснийг Вадим

“гэмээн цайруулжээ” гэж егсөн. Вадим одоо зохиолчид, найрагчид, алдартай зохиолчид, алдартай найрагчидтай танимгайрхах болсон, олон тийм хүн тэднийхээр орж гарна.

Вика зочдоо хүлээж авна, гэхдээ тэдний ярианд оролцоход түүнд хэцүү. Тэрээр, үнэнийг хэлэхэд, юу ч уншихгүй: Гавшгайчид, манлайлагчид, үйлдвэр завод, ган ширэм гэхчилэн уншихад нэн уйтгартай. Гэхдээ юм мэдэхгүйгээ өөртөө ашигтайгаар овжин эргүүлнэ. Ярилцаж байгаа хүнээ илт анхааран чагнаж, түүний боловсрол мэдлэг, ой ухааныг үнэлж байгаагаа ойлгуулан шагширч дөвийлгөнө, хүн тэгэхэд хэзээ ч дуртай шүү дээ.

Нэг гуч эргэм насны жижигхэн давжаа уймраа залуу ирсэн, түүний тун саяхан нийтлүүлсэн романыг хүн болгон уншиж, хүн болгон магтана. Гавшгайчдын тухай биш, нударганчуудын тухай, тэдний бослогын тухай учраас эрхбиш уншууртай, Вика хүртэл уншсан юм байж. Харин зохиолч гуайд өөрт нь сэхээтний үнэр байхгүй, хөдөөний гэлэнгийн ч гэл үү, ламын ч гэл үү хүү. Анхныхаа амжилтад ташуурч толгой нь эргээд өөрөөсөө бусдыг сонсдоггүй, хэнийг ч олж хардаггүй болчихсон учир Вика өөрийг нь хичнээн анхааралтай сонсож буйг ойлгож үнэлэхийн оронд ухартусан түүнийг гайхшран харжээ. Уул нь дуугүй байх ёсгүй, түүний тухай, романыг нь тухай ярьж байх ёстой, дуугүй байгаад байвал бусад айлд, бусад хүмүүс романыг нь яаж магтаж байсныг өөрөө ярьж өгөх юм байж.

Вика түүнийг өөртөө татчих байсан байж магадгүй, цаадах нь даанч дорхноо алга болчихож. Вадимын егснөөр бол тэр нөхөр амжилтаа бататгах хэрэгтэй хэмээн, тэр нь ч зөв, троцкийчуудын нууц ажиллагааны тухай шинэ роман бичихээр хүн амьтнаас дөлөн оджээ.

Арай ахмад, дөч эргэм насны болов уу, бас нэг зохиолч гарч ирсэн, эвэр хүрээтэй шилтэй, хилийн чанадад аж төрж явсан петрбургийн сэхээтэн, Азийн тухай, арай басмануудын тухай гээгүй байгаа даа, хачирхам сонин бичдэг гэх. Вика ялаархсан адуу шиг толгой дохин дуу алдаж, ийм хүнтэй ерөөс уулзаж учирч яваагүйгээ байдаг чадлаараа ойлгуулахыг хичээн, овоо наашлуулж байх шиг санагдсан боловч цаадах нь бас төдөлгүй алга болчихжээ. Шинэ роман бичихээр, Дорно зүгт гэсэн үү, яваад өгч. Ийнхүү баарсаар байгаад Вика тэднийд орж гарсан хүмүүсээс хэнийг ч урхидаж чадсангүй.

Хуучин танилуудтайгаа уулзалдахаа больсон, уул нь ресторанд л тааралддаг юм, гэтэл Вика одоо ресторанд орохыг бүр цээрлэсэн, учир юун гэвэл Уран барилгач толгой өөд татах завгүй, тэгэхээр нөхрөө орхин ресторан хэсэх юм бол өөртөө өргөмжилсөн нөгөө дээдсийн хүрээлэнгийн хатагтайн дүрээ баллана гэсэн үг.

Ноэми, Нина Шереметева хоёртой (түүнийг бодвол цэнгэлтэй амьдарч байгаа хоёр доо) утсаар баахан бурна, харин айл хэсэхийн хувьд бол баян франц худалдаачинтай суусан Нелли Владимирова дээр л очно.

Тэр паравгар уруултай, доожоогүй франц суунаг талимаа нүдээрээ хүүхэн эргүүлдэх санаатай, оросоор бараг ярихгүй, эсвэл ярьдаггүй дүр эсгэх хэрнээ, гэнэ гэнэ “си”, “до”, “ре” гэдгийг нь цохож байгаад “Марья Сидоревна, Марья-си, Марья-до, Марья-ре” гэж цочир хашгичин дуулж, мангар юм шиг инээнэ. Вика түүнд дургүй.

Харин байр нь их гоё, бөөн хивс, эртний тавилга, ваар шаазантай, бас хувийн машинтай,

хувцас эсвэл гадаадын новш, мөн ч их новш бий. Жорж чухам ямар ажил эрхэлдгийг хэн ч мэдэхгүй, Нелли бас булзааруулаад хэлэхгүй, гэхдээ баян гэдэг нь үнэн байх.

Товчдоо, Неллигийн аз дайрчээ. Өөрөө ямар гээч? Азрага л гэсэн үг! Биерхүү ч, ясархуу ч. Гэтэл харчууд түүн рүү хошуураад салахгүй. Тэгээд л Жоржийг уургалчихсан, түүний дөнгөж хүзүүгээр хүн шүү дээ. “Чи энүүнийгээ шөнө дараад бүтээчихгүй биз?” гэж Вика цаашлуулахад Нелли, “Битгий санаа зов, манай хүн сэргэлэн, хэвтэрийнхээ эвийг бид олно шүү” гэх.

Нелли хоёр ч удаа Парис явж нүд тайлаад, гэр орноо европ маягт оруулсан. хүн зочлохдоо эхлээд элдэв хүйтэн юм уулгана, зууш нь есөн шидийн юмаар хачирласан хумсын чинээ талхнууд, машинаа өөрөө барина, нэг үгээр хэлэхэд, европжсон төдийгүй бүр америкжсан, нэг шүүрснээ тавихгүй шургуу хүүхэн, яльгүй хашгичуур, гэхдээ ажилсаг, унших юмаа ч амжуулна, бас зураг зурна... Нэг дон бий: морины уралдаан мөрийтэй үзэж дандаа хожно. Бас шаггүй овжин, хуучин хувцас хунараа сүйхээтэй борлуулна, гэхдээ дамлахгүй, зүгээр л урт нь ч юм уу, өнгө нь ч юм уу таараагүй гэдгээр илүүдсэн юмаа найз нартаа зарж байгаа царайлна. Лхагва гаригийг гэртээ найз нараа цуглуулдаг уламжлалт өдөр болгосон.

Гэхдээ хамгийн гол нь тэднийхээр олны хөл тасрахгүй, голдуу гадаадынхан шүү. Энэ л Викад эрхбиш горьдлого төрүүлнэ. Нелли хэн хэдэн настай, ямар сонирхолтой, ямар боломжтой гэхчилэн бараг хүн болгоны тухай түүнд ярьж өгнө, заримдаа хэн нэгний далан булчирхайг тоочиж муулах нь ч бий.

Олон зочин Вика руу хараа чулуудавч эхлээд тун шалихгүй амьтад таарч байжээ. Бараг бүгдээрээ эхнэртэй. Вика тэдэнтэй зин-даагаа бодон жирийн найрсаг харьцахдаа эргүүлэх оролдлогоноос эвлэгхэн зайлсхийхийн хамт, “Бие хүн хэн болохыг тодруултал” үүссэн харьцааг сох таслахгүй. “Бие хүн” хүсэлд нийцэхгүй нь тодорвоос анх танилцахдаа үлдээсэн бяцхан горьдлогоо сурамгай замхруулна.

Вика Шарльтай чухамхүү Неллигийнд тааралджээ.

Цайвар шаргал үстэй, өндөр нуруутай, хундага барьсан тэр хүн Жоржид нэг юм яриад зогсож байжээ.

түүний хүдэр царай, цохноосоо бөгтөр хамар Викагийн нүдэнд шууд тусчээ. Сайхан таарсан гоё костюмыг нь бас анзаарсан. Иймэрхүү их гарын шонхор Неллигийнхээр үзэгдэж байгаагүй дээ. Язгууртан уу? Өөрийг нь хэдэнтээ шимтэн харсан харцаар нь тэдний хооронд гал авалцлаа гэдгийг Вика ойлгожээ. Тэрээр эрчүүдийн ичгүүргүй тэмтрэх харцыг жинхэнэ и р э э д ү й т э й харцнаас ташаарахгүй ялгана.

Маргааш нь Неллитэй хов живээр “хэл амаа билүүдэж” байхдаа Вика Шарлийн тухайд,

-Цайвар үстэй франц тэр болгон таардаггүй биз дээ гэжээ.

-Францын язгууртнууд бүгд ёс шиг цайвар үстэй. Ер нь хойт зүгийн ялангуяа зүүн хойт зүгийн францчууд герман цустай учраас бүгд цайвар үстэй байдаг юм гэж Нелли тайлбарлав.

Тэрээр францтай суусныгаа францаар мэрэгшсэн гэж үздэг нэгэн.

-Тэр язгууртан уу?

-Тийм үг таарахгүй. Тэр бол гүн хүн, овог нь “де” гэдэг угтвартай бичигддэг юм.

-Үгүй ер хэмээн Вика инээд алдав. -Гүнтэн Москвад юу хийдэг байхав?

-Шарль сурвалжлагч гээд Нелли францын нэг алдартай сониныг нэрлэж, -Тэдний гэр бүл энэ сонины эзэмшигч, францын цуутай баячуудын нэг. Шарлийн сүйт бүсгүй нь нэг санхүүчийн охин, Ротшильдынх биш, гэхдээ тэр зиндааных, би овгийг нь мартчихаж гэв.

Тэгэхээр Шарль царайлаг, баян бас г а н ц б и е байх нь. Католик сүсэгтнүүдэд гэр бүр салах хориотой учраас эхнэргүй гэдэг бол ноцтой зүйл.

Вика гэртээ очоод бүх юмыг нарийвчлан тунгаажээ. Энэ боломжийг алдаж болохгүй. Дьяков, Шарок хоёр саад хийснээс болж Эрикийг алдсан удаатай, одоо түүнд юу ч саад болох ёсгүй. Энэ улс оронд түүнд хийх юм даанч алга. Увайгүй явдал, атаа жөтөө, уриа лоозон, сүрт жагсаал, тодорхойгүй маргааш, үүрдийн айдас энэ тэрээс залхахын цаагуур залхаж гүйцлээ. Тэрээр өнөөдөр Москвагаар сэлгүүцэж явна, гэтэл маргааш утасдаад, нөгөө түрүүчийнх шиг: “Иргэн Марасевич, тантай ДЯАКГ-аас ярьж байна...” гэж мэднэ. түүнийг тэндээс тавьсан нь чухал биш, дахиад дуудаж болно, дахиад албадаж ажиллуулна. түүний өгсөн баталгаа тэд нарт байгаа юм чинь.

Парис руу арилж өгөх хэрэгтэй. Мөнхийн их Парис. Сургуульд байхдаа франц хэл үзэж байсан, үнэндээ яггүй мартсан л даа, гэхдээ эргээд үзэхэд сэргэнэ... Нэг шүлэг чинь юу билээ?.. “Bonjour, madame San-Souci, combien content ces saucisses”.* Гол нь дүрэм, Тэрээр дүрмийг амархан сэргээгээд авна, present, passe compose, passe simple, futur simple, participe passe ** гэж юун төлөө есөн жил балбалаа. Үйл үгийн хэвнүүд бага насыг нь санагдуулж Вика бүр сэтгэл нь догдлоод явчихав.

Юу ч болсон хамаагүй эндээс явна. Уран барилгач өнөө маргаашгүй бултчихна, аав нь эрт орой хэзээ боловч нас барна, уул нь эртхэн л бол дээр сэн, тэгсэн цагт мань хүүхэн хаашаа харж юугаа

*.“Хатагтай Сан-Суци гуай сайн байна уу, харин энэ зайдас ямар үнэтэй билээ?”

** .Үйл үгийн хэв: одоо цаг, үргэлжлэн өнгөрсөн цаг, энгийн өнгөрсөн цаг, энгийн ирээдүй цаг, өнгөрсөн цагийн үйлт нэр.

маажих вэ? Вадимтай бол одоо ч гэсэн нэг дор хооллохын арга байхгүй, идэмхий байгаа, шалир шалир зажилж байгаа энэ тэр нь ой гутам, нэмэрт нь ам дүүрэн байж айварлахыг яана.

Хариугүй цалинтай нэг муу инженертэй сууж насаараа хуруу хумсаа хуйхлах уу. Үгүй ээ, энэ их гүрэн түүгээр дутахгүй. Тэр муу азрага шиг Неллийг Парис руу аваад явчихаж байгаа юм

чинь түүнийг, Викаг бол бүр уухайн тас авна.

Энэ удаа л нэг бузгай юм болж магадгүй. Тэрээр хархүүгийн шимтсэн харц, дуугарахгүй байсан энэ тэрийг эргэж саналаа, уул нь францчууд их аманцар, гэтэл Шарль түүний дэргэд огт дуугарахгүй, цаанаа нэг учиртай чимээгүй байсан. Чухамхүү энэ л Викад горьдлого төрүүлнэ.

Ухаантай хүүхэн цайллага дуустал хоргоддоггүй учраас Вика Неллийгийнхээс хамгийн түрүүнд, зүгээр ч үгүй, англи маягаар хэнтэй ч баяртай гэлгүй, учир битүүлэг явчихжээ.

Гэртээ улаа бутраад баяр хөөртэй иржээ. Гэрийн цамцтай Уран барилгач тавхайгаа чирсээр очиж хаалга онгойлгож өгөв. Царай нь цонхигор, нүд нь сэлхгэр харагдана.

-Чи хүрээд ирэв үү. Би бүр унтах гэж байлаа.

Вика булган хүрмээ түүний гар дээр тохоод, хацар дээр нь шопхийлгэн үнсэв.

-Хонгор минь, зүйтэй шүү, чи их ядарсан царайтай байна... Би халуун усанд жаахан хэвтээтэхье.

Неллийг энэ хэрэгт оролцуулах уу, хэрэггүй юү? Викагийн бодлыг эзэмдсэн юм энэ.

Үгүй ээ, одоохондоо хэрэггүй байх. Ганцхан гоомой дохио, дэмжсэн үг, саймширсан инээмсэглэл бүх юмыг баллаж мэднэ. Шарль Неллигийн дахиад үзэгдэхгүй болчихвол өөр хэрэг л дээ. Гэвч лхагва гариг хүртэл хүлээе.

Хэрэв Шарль ирвэл үнэхээр гал авалцсан гэсэн үг. Тэгвэл

Неллигийн хэрэг гарахгүй.

Дараачийн лхагвад Шарль Неллигийн иржээ.

Мэдээж, Вика ч ирж. Гэхдээ урьдын адил бусдаас арай хожуу...

1935 оны долдугаар сарын 7-нд Сталин Үндсэн хуулийн комиссын бүгд хурлыг даргалав.

Комисс гучин хүнтэй, Сталин гучин нэгдэх нь. Намаас хөөгдөж, бүх албан тушаалаасаа авахуулсан Авель Енукизегээс бусад нь бүгд байв. Хайнга хандсанаас болж түүнийг Үндсэн хуулийн комиссоос хасаагүй тул албан ёсоор бол гишүүн хэвээр байгаа юм.

Бухарин, Радек хоёр шинэ Үндсэн хуулийн үндсэн төслийг зохиогчид учраас гол илтгэгчид. Бусад нь ч үг хэлэх нь мэдээж. Тэгэлгүй яахав! Тэгээд “Үндсэн хуулийн эцэг” хэмээгдэн түүхэнд орох юм чинь.

Эхний илтгэгч Бухарин.

Бухарин хоёрдугаар сард Бүх холбоотын гавшгай хамтралчдын хоёрдугаар их хурал дээр үг хэлэхдээ, “Улс орон тэр даяараа ленинч намаа тойрон нягтарч, энэ намыг хөдөлмөрчдийн гайхамшигт удирдагч, сая сая хүний жанжин, нэр нь аугаа их таван жилүүд, аварга их ялалтууд, аврага том тэмцлийн билиг тэмдэг болсон Сталин төмөр мэт гараар жолоодож явна” гэсэн билээ.

Гэтэл яг долоо хоногийн дараа “Правда” сонины нийтлэсэн “Пролетарийн жанжин” гэдэг өгүүлэлдээ Радек Сталиныг шагшин магтах тухайд нөгөө Бухариныг хол хаяжээ. Ямар сайндаа түүнийг Крадек гэгцгээх вэ дээ, сармагчин царайлсан хулгайч, луйварчин.

Зиновьев, Каменевын явдал давгагдаж байна уу? Тэр хоёр ч бас түүнийг дэвэргэн магтаж байсан, харин юугаар төгслөө дөө?

Заль л даа. Бухарин “Төслийн үндсийг” илтгэв. Үндсэн хууль байж болох бүх эрх чөлөө, дэлхийд хосгүй аугаа их эрхээр ард түмнийг хангах ёстой, түүнчлэн бүрэн тэгш эрх, дэлхийд хамгийн ардчилсан сонгуулийн систем, дэлхийд хамгийн шударга шүүн таслах ёс...

Бухарин, Радек хоёр ингэж сэргэлэнтлээ.

мань хүн хүртэл тэднийг ийм аданга чинээ санаагүй. Дэлхийн хамгийн ардчилсан үндсэн хуулиудыг даваад явчихаж. Гэнэн толгойнууд. Ийм Үндсэн хуулиар хаацайлан эхэн үедээ өөрснийгөө аюулгүй болгож, амар жимэр байцгаана, хожим нь засгийг “үндсэн хуулийн аргаар” солино гэж горьдоцгоож байна. Дүйрэнгүүд!

Энэ Үндсэн хууль түүнд, юуны өмнө түүнд л хэрэгтэй. Мөд хийх гэж буй боловсон хүчний хувьсгалд энэ хууль улс төрийн хүчирхэг халхавч болно. Засаг нэг хүний гарт байгаа цагт, тэр засаг бат бөх байгаа цагт, ард түмэн тэр засгийг дэмжиж байгаа цагт ямар ч Үндсэн хууль дүйнэ.

Ард түмэн түүнтэй хамт байгаа. Өлсгөлөн, гуйланчлалыг үл харгалзан, сая сая хүний амь хохирсоныг үл харгалзан ард түмэн түүний төлөө байна. түүнээс айцгааж байна. Нэг хүний засаглалын гол нөхцлийг хэрэгжүүллээ. Ард түмэн зовлон зүдүүрийнхээ бурууг бурхнаас

бусад хэнд ч хамаагүй тохож ирсэн түүхтэй. Бурханыг зэмлэж зүхдэггүй, бурханд талархан сүсэглэдэг.

Сталин ийнхүү бодолхийлэх зуур Бухариныг анхааралтай сонсож суув. Ер нь ч, түүнийг цөмөөрөө, ялангуяа үндэсэрхэг үзэлтнүүд анхааралтай сонсоцгоож байлаа.

“Намын шилдэг онолч”, “намын хайрт” өөрсдийнх нь өмнө үг хэлж байгаад хөөрч уяран мэлэрсэн тэд нар түүний учир авцалдаа төгс, хэллэг томъёолол гойд илтгэлд бах нь ханаж байна гэлтэй. Туркмений Айтаков бүр амаа ангайчихаж, Буриад Монголын Ербанов цаггалан муур шиг нүд нь талимаарчихаж. Уул нь үндсэрхэг үзэлтнүүд. Өвөр Кавказын Ардын Комиссаруудын Зөвлөлийн дарга Мусабеков ч үндэсэрхэгч, Таджикстаны Рахимбаев ч үндсэрхэгч, чантуу Икрамов, Файзулла Хожаев хоёр ч үндсэрхэгчид. Бухарин холбооны улсуудын бүрэн эрхт байдлын тухай айварлахад тэдний нүд цахилж гялалзаад явчихлаа. Тэдний хувьд Бухарин урьдын адил “жолоодогчоороо” байна. Бухаринд шинэ Үндсэн хууль бэлтгэхийг даалгаснаар мань хүн түүнийг удирдлагын бүрэлдэхүүнд буцааж оруулжээ гэж найдацгааж байна. Тэд нар үнэхээр тэгж хүсч байна. Өөрснийгөө биеэ даасан, хараат бус байдалтай гээд итгэчихэж, муусайн засаг ноёдууд!

Энд сууцгааж байгаа Белоруссын Голодед, Червяков, Украины Любченко, Петровский, Чубарь нар тэд нарын өрөөсөн гутал... Танигдаагүй, найдваргүй хүмүүс.

Тэрээр алагдсан Киров, нэгдүгээр сард нас барсан Куйбышев хоёрын оронд Улс төрийн Товчоонд Чубарь, Микоян хоёрыг оруулжээ.

Микоян зальт, илбүүрч этгээд, гэхдээ ӨӨРИЙНХ нь зальт, илбүүрч этгээд, бас сайн ажилтан. 1918 онд Бакуд яаж амь гарсан нь тодорхой бус. Бакугийн бүх комиссар алагдсан байтал нөхөр Микоян амьд үлдсэн. Хачин шүү, тийм биз дээ? Энэ хүн үнэнч зүтгэнэ ээ.

Чубарь ойлгомжгүй л дээ. Гэхдээ Петровский тэр хоёрын нэгийг сонгохоос өөр замгүй болсон, хоюулаа 1926 оноос УТТ-ны орлогч гишүүд, тэрэндээ хүрэхээр Петровскийгээс Чубарь дээр. Чубарь ойлгомжгүй, гэтэл Петровский бол хүний хүн, ӨӨРИЙНХ нь хүндэт хадам Аллилүев шиг идеалист марксч.

Бас энд сууж байгаа зарим орос ч танигдаагүй хүмүүс.

Жишээ нь Акулов байна, халзан, монголтой төстэй шүү, бас

прокурор байхдаа Вышинскийд саад хийгээд байсан, тэгээд түүнийг Енукизегийн оронд ТГХ-ны нарийн бичгийн даргаар сонгуулж, Вышинскийг прокуророор томилж, татлаа түлхээгүй болгосон. Уул нь Вышинский ёстой увайгүй шаар, гэхдээ хэрэгтэй шаар, одоо тэр харахгүй юу, Бухарины илтгэлд хөөрөөгүй дүр гаргаад хөмсөг зангидчихсан байна, ӨӨРТ нь зориулж тийм дүр эсгэж байгаа юм, бүгдийг ойлгоно, хичээнгүй халимагтай, нямбай танасан буурал сахалтай мал, харваас үнэтэй костюм, цардмал захтай цамц, зангиа энэ тэр нь европ сэхээтний дүрд хувилчихсан буй хэрэг, гэтэл дотроо бол эрүүгийн хэрэгтэн. Крыленког нэг нүдээр үзэхгүй, зажлахгүй залгихад бэлэн хэрнээ гэнэ гэнэ түүн рүү зулгуйдан инээмсэглэнэ.

Крыленко зайлбаргүй дайсан. Хүүхдийн эрүүгийн хариуцлагын асуудлаар юу шиг байлаа? Дайсан шиг.

Наймдугаар сарын 7-ны өдрийн хуулийг эс харгалзан улсын эд хөрөнгийг, ялангуяа тээврийн байгууллага дээр шамшигдуулсаар байна. Гол тонуулчид нь хүүхдүүд. Ягода сүүлчийнхээ мэдээлэлд энэ тухай онцгойлж дурдсан байна лээ. Хоёрдугаар сараас төмөр замын тээврийг тэргүүлсэн Каганович бас үүнийг нотлосон байна лээ.

Гэтэл хүүхэд шүүгдэх ёсгүй.

Тэгж яривал яахаараа шүүгдэх ёсгүй билээ?

Хулгай хийж болохгүйг арван хоёртой бандь сайн мэднэ, хулгай гэмт хэрэг гэдгийг ч сайн мэднэ. Гэтэл тэр бандь өөрийг нь шүүх ёсгүйг бас мэднэ. Тийм учраас түүнийг шүүж болно, шүүх ч ёстой гэдгийг мэдэж аваг.

Бас хүүхдүүдээ хулгайд явуулдаг эцэг эхчүүд ч үүнийг мэдэж аваг. Ялын дээд хэмжээ хүртэлх аливаа эрүүгийн хариуцлага арван хоёр настайгаас эхлэн бүх иргэдэд хамаарна гэсэн нэмэлт эрүүгийн хуулинд хэрэгтэй байсан юм. Тэгж гэмээ нь хулгай хийхээ болино, ард түмний хөрөнгийг үрэн таран хийхээ болино, дээрэмдэх, алахаа болино. Ингэвээс эцэг эхчүүдэд нь ч сайн сэрэмжлүүлэг болно. С а й н м у у б ү х э ц э г э х ч ү ү д э д.

Гэтэл шүүхийн Ардын комиссар Крыленко тийм зарлиг гаргахыг эсэргүүцсэн. Бүр ӨӨРТЭЙ нь уулзах гэж гүйснийг яана. мань хүн түүнийг, мэдээж, хүлээж аваагүй. Тийм хууль хаа ч байхгүй, дэлхийн шүүхийн практикт тийм жишиг байхгүй, дэлхийн нэг ч улсад арванхоёртой хүүхдийг цаазладаггүй, хүүхэд гүтгэлгийн золиос, тэр ч байтугай эндүүрлийн золиос ч болж мэднэ, Зөвлөлт засгийн арван найм дахь жил дээр ийм зарлиг гаргавал хилийн чанадад ёрын муухай сэтгэгдэл төрүүлнэ, Зөвлөлт төрийн нэр хүндийг гутаана гэж Крыленко зүтгэсэн тухай холбогдох газрын баттай мэдээ түүнд бий.

Нөхөр Крыленко юунаас болоод гэнэтхэн ийм хүнлэг болчихов, юунаас болоод хөрөнгөтний олон нийтийн санаа бодлыг хэрэгсдэг болчихов?.. Урьд өмнө Аж үйлдвэрийн намын хэрэг, меньшевикүүдийн хэрэг болон бусад шүүн таслах ажиллагаанд яллагчаар оролцож байхдаа тийм юмыг хэрэгсдэггүй л байсан даа.

Нөхөр Крыленко тун саяхан “Шүүхээс туйлын бодит байдлыг шаардах нь хольцгүй үл гүйцэлдэх үзэл” хэмээн нотлож, түүний тэр үедээ зөв ярьж байсанчлан зөвлөлтийн шүүх яллагдагчийг өөрөө өмгөөлдөг учраас өмгөөллийн эрхийг хязгаарлахыг шаардахын зэрэгцээ эрүүгийн байцаан шийтгэх хуулийг “хөрөнгөтний эрх зүйн хуулбар” хэмээн бараг л бүрмөсөн халах шахуу санал тавьж байсан билээ.

Гэтэл гэнэтхэн зуун наян хэм эргэчихжээ. Үзэл бодлоосоо ил тод татгалзаад зогсоогүй ноднин “Ленин шүүх, эрүүгийн бодлогын тухай” гэдэг номны оронцог гаргаж, хувьсгалт хууль ёсыг сахих хөдөлбөргүй бодит нотолгоо гаргах, байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг чанд мөрдөх... гэхчилэн номносон. Энэ бүхэн шүүх, прокурорын өнөөгийн шатны зорилтыг зөв ойлгож байгаа Вышинскийн эсрэг, намаас дайснуудтайгаа хийж буй тэмцлийн

эсрэг чиглэж байна.

Крыленко меньшевикүүдийг шүүсний яг дараахан Шүүхийн Ардын Комиссарын газар очих хүсэлт тавьсан юм. Ойлгомжтой. Хэрэг явдал хаашаа хэвийж буйг мэдсэн, шүүн таслах ажиллагаанд дахиад оролцох хүсэлгүй гэсэн үг. Намын гаднах дайснуудтай тэмцэж ирсэн, харин намын доторхи дайснуудтай тэмцэхгүй гэж буй хэрэг. Вышинскийн нэрийг сэвтүүлэх гэж оролдсон.

Вышинский бол хэрэгтэй хүн. Вышинскийд большевик намтай хэлхээ холбоо байхгүй, тийм учраас намын доторхи дайсантай тэмцэхэд илүү тохирно. Хэрээ мэднэ, одоо хүртэл чичрээд айдас нь гараагүй, ямар ч даалгаврыг биелүүлэхэд бэлэн буй хүн.

Харин Крыленко бол өөрийгөө мундаг гээд биеэ тоочихсон хүн, намын 1904 оны гишүүн, манай анхны Дээд Ерөнхий командлагч, Дээд шүүхийн анхны дарга, өндөр ёс суртахуунтай, үзэл сурталтай хувьсгалч юм гэнэ. Нэмэрт нь тамирчин, уулчин. Ахмад большевик мөртлөө Памирын хаа нэгтэй уулаар мацаад л. Шатарчин. Энэ саваагүй зугаагаар хайран цагаа их үрсэн Ленинийг дуурайж байгаа нь тэр.

ХҮП их хурлаас Крыленког ТХ, НХШХ-ны алинд ч сонгоогүй. Энэ бол сануулга. Гомдсон. Дүгнэлт хийгээгүй. Өнөөдөр түүний 50 насны ой. Уулчдынхаа мэндчилгээг “Правда”-гаас уншина биз. Төв Хороо түүнд баяр хүргэх бодолгүй байна. Бас л сануулга. Сүүлчийнх. Үүнээс дүгнэлт хийх нь үү, эсвэл дахиад л Вышинскийд чөдөр тушаа болоод байх нь уу, харъя. Хүмүүс хоорондоо зүгээр л хэл амаа ололцохгүй байгаа бол сайн хэрэг, түүнд хэр үнэнч гэдгээрээ уралдаж буй нь тэр. Крыленко, Вышинский хоёрын тухайд тийм юм байхгүй. Вышинский түүнд үнэнч, айсандаа үнэнч байгаа, гэхдээ л үнэнч. Крыленко-үнэнч биш. Тэр троцкийчууд, бухаринчууд мэтийн сөрөг хүчнийхэнтэй нийлж байгаагүй. Гэхдээ тэдний эсрэг бас үзэлцэж байгаагүй. Найдваргүй хүн. хүний хүн. Тэгэхээр энэ хүн боловсон хүний хувьсгалын галд амиа алдана.

хүний хүн ч олон, найдваргүй хүн ч олон байна. Энд өөрийг нь оруулаад 30 хүн сууж байна. Тэрээр эдний хэнд нь их бага ч гэсэн багтай найдаж чадах сан билээ? Ворошилов, Жданов, Каганович, Мехлис, Микоян, Молотов. Энэ хэд вэ? 29-ийн 6. За яахав, муу увайгүй Вышинский долоодох нь, 29-ийн 7, дөрөвний нэг нь ч хүрдэггүй.

Ямар ч гэсэн төвийг сахих нь хэн байна? Энэ бол “алтан хөмрөг”, энэ бол намд удсан амьд хүүрнүүд: Красиков, Стасова, Калинин, Литвинов, Петровский... Үгүй ээ, Петровский биш, мань хүн яаж ч байж мэднэ. Петровскийн хүү Петр намаас хөөгдсөн, цөллөгт байгаа, түүнийг аль хэдийн буудан хороох хэрэгтэй байсан юм. УТТ-ны орлогч гишүүн эцэг хүүгээ яагаад ийм болгочихов?!

Ингэхээр “дундыг баригчид”-4, найдвартай хэдтэй нийлээд арван нэг.

Үлдсэн арван найм нь? Тэднээс дайснууд нь Бухарин, Радек, Крыленко, Уншлихт дөрөв. Бусад нь найдваргүй хүмүүс: Акулов, Бубнов, Сулимов, Чубарь, Любченко, Червяков, Голодед, Икрамов, Хожаев, Айтаков, Мусабеков, Ербанов, Рахимбаев, Петровский.

Энэ тооцоо их юм хэлж байна. Энэ бол нам доторхи байдлын тусгал, ТХ дахь байдлын тусгал, тэр ч бүү хэл УТТ дахь байдлын тусгал. УТТ-нд ч найдваргүй хүмүүс бий: Оржоникизе, Рузутак, Косиор, бас Чубарь гэдэг нь одоо тодорхой боллоо.

Тэрээр Улс төрийн Товчоонд түүний талынхан олонхи байна уу, үгүй юү гэдгээс хамааралгүй байх ёстой. Нам адбиш эхлэл нь биш, ӨӨРӨӨ адбиш эхлэл нь. түүнд ил далд өрсөлдөгчийн аль нь ч байх ёсгүй. Үсэрхийлж болзошгүй аливаа аюулыг үндсээр нь устгавал зохино. Засгийн оргил руу тэмүүлэх эрх нэг ч хүнд байхгүй. Манай орны оршин суугч болгон үүнийг ойлгохын тулд өөрийнх нь оршин тогтнох, эрх чөлөө, аюулгүй байдалд хөндлөнгөөс заналхийлж байгааг мэдэрч байх ёстой. Үг дуугүй захирагдвас сая аюулгүй байдал нь хангагдана гэж ойлгох ёстой, алан хядлага тасралтгүй үргэлжлэх ёстой, тийнхүү үргэлжилж удирдлагын хэвийн дассан арга барил болох ёстой.

Хөдөөнийхөнд тэндхийн эзэн хэн гэдгийг үзүүлэхийн тулд гучаад оны өлсгөлөн шаардлагатай болсон. Өлсгөлөн сая сая хүний амь насыг залгисан боловч ялалт авчирсан.

түүний засаглал бас сая сая хүний өртөгтэй байх болно, гэхдээ улс орны эзэн хэн гэдгийг Тэрээр ард түмэнд үзүүлнэ, энэ орны эзэн хэн гэдгийг Тэрээр бүх дэлхийд харуулна.

Анхны алхам хийгдлээ. Кировыг алсны төлөө Тэрээр хайр найргүй хариу цохилт хийж, улс оронд айн сүрдэх уур амьсгал бий болголоо. Хамгийн хүчтэй цохилт Ленинградд туссан. Энэ хот хоёрдугаар нийслэлийн байдлаар дахиад хэзээ ч сэргэхгүй. Улс орон даяар намын гишүүний баримт бичгийг шалгах ил шалгалт, намын гишүүн болгоныг ДЯАК-ын шугамаар шалгах далд шалгалт зэрэгцэн явж байна. Янз бүрийн сөрөг хүчинд оролцож явсан хүмүүс, өөр намын болон харш ангийн гаралтай хүмүүс, хаант засгийн түшмэл, офицерүүд, санваартнууд, хуучин нударган болон тэдний гар хөл бологсод, зөвлөлтийн эсрэг үзэл бодолтой бүх хүнийг шүүрдэн барьж, нийгмээс тусгаарлах буюу шаардлагатай бол устгаж байна. Энэ бүхэн цар далайц нь л бага болохоос түрүүн ч байсан. Гол юм цаашдаа болно.

Зиновьев, Каменев хоёр Кировын аллагад ёс суртахууны хариуцлагатайгаа хүлээсэн. Ямар зальжин, ямар хоёрдмол санаатай томъёоллоор хүлээсэн гээч: “Бодит байдлын улмаас хуучин сөрөг хүчнийхний урьдын үйл ажиллагаа энэ гэмт хэрэгтнүүдийг зөвхөн ялзрал руу хөтлөсөн байж болно”.

Улс төрөөр домоглогчид! Ийм овоор аврагдана гэж бодоцгоож... Гэхдээ яг тэр мөчид тэднээс илүү юм салгах боломж байгаагүй. Кировын алуулсныг бушуухан ашиглах хэрэгтэй байсан болохоор шүүн таслах ажиллагааг ч бас хойшлуулах арга байгаагүй. Зиновьев, Каменев хоёр хэргээ хүлээснээр тэднийг тусгаарлах боломжтой болсон. Гэвч тусгаарлалт бол дутуу арга хэмжээ. Троцкийчуудыг тусгаарлаад таван жил болчихоод байхад тэд нар цагаа хүлээсээр л байна. Шоронгоос хаан ширээ хүртэл ганцхан алхам байдгийг түүх харуулж байна. Ийм учрал тохиолдохгүйн тулд замд нь цаазын тавцан байх ёстой.

Кировыг алсны төлөө ёс суртахууны бус эрүүгийн хариуцлага байх ёстой. Зиновьев, Каменев хоёр ү й л д с э н хэргийнхээ төлөө ял заагдсан байх ёстой.

Хөрөнгөтний сонинууд нэгдүгээр сарын шүүн таслах ажиллагааг хаалттай явагдсан гэдгээр

шалтгаацан хүлээн зөвшөөрөөгүй. Донгосогч Мирабогийн “Намайг шүүх шүүгч алагчилдаг, сувьдаг, тэр ч бүү хэл миний дайсан ч байсан хамаагүй, гагцхүү намайг ил шүүгтүн” хэмээсэн алдарт үгийг иш татан дүвчигнэцгээсэн.

Тэг л дээ! Сайн байна! Тэд тэр ил шүүх хурлаа, нээлттэй шүүн таслах ажиллагаагаа авцгааг. Зиновьев, Каменев хоёр гэмт хэргээ бүх дэлхийн нүүрэн дээр хүлээх болно. Тэд Кировыг алах тушаал өгснөө, нам, засгийн бусад удирдагчийг алах бэлтгэл хийж байснаа хүлээх болно. Чухам тийм учраас тэднийг тусгаарлах бус устгах ёстой. Устгах ч болно.

Зиновьев, Каменев хоёр хэрэг хүлээх болов уу? Амь насыг хэлтрүүлэхээр амлавал хүлээж таарна. Амьдрал байгаа цагт засаг авах горьдлого байна. Амьдралаас хагацмагц тэд тэр горьдлогоо үүрд гээнэ. Хэрвээ зөрүүдлээд байвал залхаан цээрлүүлэх албаны нүсэр нударга, төрийн нүсэр нударга тэр чигээрээ тэдний толгой дээр бууна. Тэсэхгүй. Үүнийг тэд тэсч чадахгүй. Тэдний гэр бүл, тэдний авгай, хүүхдүүд барьцаалагдчихна, эхнэрээ гэх нөхөр, үрсээ гэх аав нар юм чинь, үүнийг бас тэсэхгүй.

За, ЗСБН Узбек Улсын АКЗ-ийн дарга, ЗСБНХУ-ын ТГХ-ны Узбекистаныг төлөөлсөн нэг дарга Файзулла Хожаев энэ үг хэлж байна. Ийм хүн амьдралаас татгалзана гэж байх уу? Шингэхэн царайтай сайхан эр, ийм гоё харчуулыг эртний персийн бичил зурагт дүрсэлсэн байдаг даа.

Тансаглана, гэрээ бөөн хивс, үнэтэй элдэв чамин юмаар дүүргэчихнэ, эрдэнэсээ бол нуучихсан байгаа байх, Бухар, Самаркандынхан цөмөөрөө алмаас эрдэнэ хураадаг юм чинь.

Ингэхэд, Файзулла Узбекистаны ТХ-ны нарийн бичгийн дарга Икрамовтой хэл амаа ололцохгүй байгаа. Файзулла язгууртан, нөгөөдөх нь харц, гэхдээ ичгүүргүй мугуйд харц. 1929 оны оны 4 дүгээр сард, БХК(б)Н-ын ТХ, ТШБК-ын хамтарсан Бүгд хурал дээр түүнийг нэг зүйл анхааруулахад, “Нөхөр Сталин, эцсийн эцэст та миний үгийг дуусгуулах юм уу, үгүй юм уу?!” гэж эгдүүцэж байсан.

Икрамов Бухарины найз, Бухарин ноднин Узбекистанд амрахдаа тэдний гэрт буудалласан. Тийм учраас Икрамов ирээдүйд Бухарины хажууд байраа эзлэнэ, Файзулла ч бас тийш нь хийчих хэрэгтэй, Икрамовтой хоёр биенээ живүүлж байг. Нөхөрлөл ч бай, дайсагнал ч бай, орчлон дээр бүх юм урваж хөрвөнө.

Хожаев болон комиссын бусад гишүүд үг хэлж байх хооронд Сталин ийнхүү бодлогоширч суув. Тэрээр зөвхөн Бухарин, Радек хоёрыг л бүрэн сонссон, тэд бол зохиогчид, бусад нь гагцхүү түүнд дуу хоолойгоо сонсгох гэсэн чалчигчид. Орон нутгийн Зөвлөлүүдийн үүрэг гэхчилэн элдэв балай юм бурцгаана, энэ бүхэн ёстой сонирхолгүй зүйл учраас Тэрээр тэднийг ойшоож сонсохгүй байгаа юм.

Шинэ Үндсэн хуулийн гол гол чиглэлийг Бухарин Радек хоёр зүйтэй тоймлосон байна.

Энэ бол өнөө болон хожмын үеийнхэн Зөвлөлт төрийн нүүр царай, түүний ардчилсан нүүр царай, ард түмнийх нь аугаа их эрх чөлөөний тухай үнэлж дүгнэх баримт бичиг. И й м Үндсэн хуультай байхад алан хядлага, хууль цаазгүйдэл энэ төрийн тухай аливаа яриа муйхар

гүжирдлэг болж харагдана.

Энэ Үндсэн хууль олон улсын тавцан дээр асар том хожоо өгнө. Шүүх хурал, шүүн таслах ажиллагаа цаашид ч болно, гэхдээ тэр бүхэн хамгийн ардчилсан Үндсэн хуулийн дэвсгэр дээр болох учраас гарцаагүй хууль ёсоор, гарцаагүй үнэн мөнөөрөө явж байгаа харагдана. Фашистын Германд болж байгаа үйл явдалтай харьцуулж авч үзвэл энэ Үндсэн хууль бүр онцгой хожоо өгнө. Гитлер бас өөрийнхөө хувьсгалыг, үндэснийхээ хувьсгалыг хийж байна, Гитлер германы ард түмнээр өөрийгөө нягт хүрээлүүлж чадлаа, тэгээд засгийн, харваас, урт настай хүчирхэг албыг бий болголоо. Гэхдээ герман маягаар түс тас дайрч, прусс маягаар дээрэнгүй загнаж, бүдүүлэг ажиллаж байна. Улс төрч, гэхдээ няхуур улс төрч биш, дэлхийн олон нийтийн санаа бодлын толинд өөрт нь хортой олон алдаа гаргаж байна.

Ийм Үндсэн хууль батлахад аюул байна уу? Засгийн эрх мэдэл намын гарт үлдэх учраас, тэгснээрээ түүний гарт үлдэх учраас ямар ч аюул байхгүй. Энэ бол б о д и т эрх мэдэл. Үндсэн хуулиар үүнийг хуульчлах хэрэгтэй. Коммунист нам Зөвлөлт төрийн удирдан чиглүүлэгч хүч мөн гэж Үндсэн хуульд шууд хэлэх хэрэгтэй. Харин нэр дэвшүүлэхийн хувьд зөвхөн нам төдийгүй үйлдвэрчний эвлэл, комсомол бусад олон нийтийн байгууллага оролцоно. Тэдгээр нь коммунист нам, эдгээр байгууллагуудын эвслээс нэр дэвшигчид болно.

Үгүй ээ, энэ буруу. Коммунист нам, бусад байгууллагуудын эвсэл гэж байж болохгүй, тэгвэл эдгээр байгууллагуудыг намтай эн дүйлгэсэн болчихно, энд ямар ч тэгш эрх, дүйцүүлэг байж таарахгүй. Эвсэл байгууллагатай биш, ард түмэнтэй байж болно.

“Коммунистууд, нам бусчуудын эвсэл” -ингэвэл л яг зөв болно.

Шинэ Үндсэн хууль манай залхаан цээрлүүлэх байгууллагуудаас илүү шуурхай, илүү сонор сэрэмжтэй ажиллахыг шаардах нь дамжиггүй. Дайснууд шинэ Үндсэн хуулийг өөрийнхөө зорилгод ашиглаж заяа нь чадахгүй, аливаа тийм оролдлогыг хэвлийд нь устгах болно.

Түүнчлэн сонгуулийн шинэ систем намын байгууллагуудаас илүү шуурхай, илүү сонор сэрэмжтэй ажиллахыг шаардах нь бас дамжиггүй. Зүгээр, шинэ нөхцөл байдалд ажиллаж үзэг, хөдлөж үзэг. Сонгууль болгон улс төрийн маш өргөн компани ажил болж байх ёстой. Өрнөдөд сонгогчид хөрөнгөтний аль нэг намын төлөө саналаа өгдөг, манайд сонгуулийн компани бол коммунист намын төлөө, Зөвлөлт засгийн төлөө маш хүчтэй ухуулга болно, нам, ард түмний эв нэгдлийг харуулсан бүх ард түмний баяр болно.

Мэдээж, шинэ Үндсэн хууль мөдхөн хийх боловсон хүчний хувьсгалд улс төрийн аятайхан халхавч болно. Гэхдээ хангалттай халхавч. Манай ялалт, амжилтыг таниулах ажлыг олон дахин нэмэгдүүлэх хэрэгтэй, ард түмний урам зоригийг харуулж байх хэрэгтэй.

Энэ урам зориг Октябрийн хувьсгалаар төрсөн нь гарцаагүй. Аливаа хувьсгал сайн сайхан ирээдүйн тухайд найдвар төрүүлдэг. Өнөөгийн зорилт бол ард түмний урам зоригийг өөрт нь харуулах, түүнчлэн зөвлөлтийн ард түмний урам зоригийг бүх дэлхийд харуулах явдал мөн.

Үүний тулд ололт амжилтын тухай хэвлэлийн байгууллагууд өдрөөс өдөрт байнга ярьж байх ёстой, ер нь зөвхөн хэвлэлийн байгууллагууд ч биш, түүнчлэн урлаг, утга зохиол, театр бүгд

зөвлөлтийн ард түмний ололт амжилтыг харуулах үйлсэд үйлчлэх ёстой, түүний урам зоригийг хөгжөөх, нийтийн үйлсэд итгэх түүний итгэлийг бататгахад тус дөхөм болох ёстой.

Дутагдлын талаар, мэдээж, бичилгүй яахав. Гэхдээ дутагдлыг юуны өмнө дайсагнагч этгээдүүдийн эсэргүүцэлтэй холбон тайлбарлах хэрэгтэй, дайсагнагч этгээдүүдийг устгах хэрэгтэй.

Сталин овсхийтэл цочлоо.

Сулимов лонхноос ус аягалахдаа аягаа алдаад таваг цохичихсон юмсанж.

Болхи годил! Аягаа ч олигтойхон барьж чадахгүй шүү. ЗСБНХОУ-ын АКЗ-н дарга гээд байгаа. Ерөнхий сайд, гэх юм уу даа... Шартчихсан юм уу?.. Бас л Тавдугаар армийнх, Иван Никитич Смирнов, Тухачевский хоёрын журмын нөхөр, харин сөрөг хүчинд нийлээгүй ээ.

Хээгүй царайлж, тэрүүхэндээ ардчилагчийн дүр эсгэнэ. Саяхан ЦУМ (Төв их дэлгүүр)-ээр орсон гэж байгаа, жирийн худалдан авагчийн байдлаар дэлгүүрийг бүтэн эргэчихээд дарга дээр нь оочерлож байж ороод, аанай л жирийн худалдан авагч шиг (түүнийг зүсээр нь таних хүн ховор) гомдол мэдүүлж, ярианы эцэст өөрийнхөө хэн болохыг хэлээд ЦУМ-ээр нэг айдас хүйдэс тарьчихсан гэж байгаа. Сонингийнхон энэ тухай бөөн сүр болгож бахдацгаасан. Орчин үеийн Гарун аль-Рашидыг олж гэнэ дээ, ээ чааваас.

Ард түмний хэрэгцээг мэдэх нэрийдлээр тэдний дунд нууцаар, танигдахгүйгээр шахцалдаж явдаг тийм удирдагчид зөвлөлтийн хүмүүст хэрэггүй... Жинхэнэ зөвлөлтийн удирдагч бол оочерт чихэлдэхгүйгээр ард түмнийхээ хэрэгцээг мэднэ. Энэ муусайн хэнз Гарун аль-Рашидууд этгээдлэх санаатай, талийгаач Кировыг дуурайна, ард түмэнд өөрийн онцлог, “ардчилсан” удирдлагын арга барилаа үзүүлэх санаатай, гэтэл Михаил Кольцов, Зорич мэтийн үзэг цаасны арандагнууд тэднийг дэвэргэн худлаа алдаршуулж байна.

Сталин Сулимов болон комиссын бусад гишүүдийг сонсохоо больж өөрийнхөө бодолд автав.

Аливаа хувьсгал хохирол авчрана, хохирол байхгүй бол хувьсгал ч байхгүй. хүн төрөлхтний бүх түүх бол хохирол: дайн самуун, байгалийн гамшиг, өвчин тахал, өлсгөлөн гуйланчлал энэ тэрд хохирогчид, сая сая хүн амь насаа алдана. Аливаа амьдрал үхлээр дуусдаг, жамын ч бай, жам бус ч бай, эртэдсэн ч бай, оройтсон ч бай, эцсийн дүндээ үхлээр л дуусдаг учраас хүн төрөлхтөн гарзныхаа тухай амархан мартдаг юм. Үхэл зайлшгүй зүйл, зайлшгүй гэдэгтэй хүмүүс нэгэнт эвлэрсэн. Хүмүүсийг үхэл рүү явуулчихсан жанжин, төр баригч, ард түмний аугаа жолоодогчийг л зөвхөн санана. хүн төрөлхтөн Александр Македонский, Юлий Цезарь, Наполеон, Суворов, Кутузов, Степан Разин, Пугачев энэ тэрийн нэрийг санаж байгаа, харин тэдний үед тэднээс болж, тэдний төлөө амь үрэгдсэн хүмүүсийн нэрийг хэн санахав. хэн ч санахгүй.

Гагцхүү хэзээч өөрийгөө зөвгөх хэрэггүй. Наполеон эрх мэдлээ тогтоогоод хэдэн зуун хүнийг үхэр буугаар буудаж хөнөөсөн. Тэднийг санах хүн байна уу? Наполеоны дайн самуунд хэдэн сая хүн эрсдсэн, тэднийг хэн ч эс мэднэ. Гэтэл герцог Энгийенскийн үхэлд өөрийгөө зөвгөхийг Наполеон оролдсон, тэгээд энэ цорын ганц үхлээс болж түүнийг түүх өнөө

хүртэл өршөөхгүй байна.

Жинхэнэ эзэрхийлэн захирагч өөрөөс хойш гашуудлын уйлаан, гаслангийн халаглал биш ёслолын сүлд дуулал, ялалтын марш үлдэх ёстой. Ард түмэн уйтгар, гуниг төрүүлэх, итгэл алдрах дуу биш, найдвар, өөдрөг үзэл төрүүлэх дуу дуулах ёстой, байдаг хоолойгоороо баяртай, чанга дуулах ёстой, аугаа их цаг үе аугаа их баяр шиг сэтгэлд хоногших ёстой шүү дээ. Соёлын ажилтнууд, яруу найрагчид, хөгжмийн зохиолчид, жүжгийн зохиолчид, театр киноны зүтгэлтнүүдэд ийм баримжаа өгөх хэрэгтэй. Аливаа гутранги үзэл, цөхрөл, итгэл алдрах, ил далдаар муучлах явдлыг үндсээр нь хайр найргүй тас цохиж байх хэрэгтэй. Ялалтын сүрт уухай ниргүүлсэн дайсны гаслааныг замхруулж байх ёстой.

Сүүлчийн чалчигч үгээ гүйцээж, санал шүүмжлэл нэг юм дууслаа.

-За тэгэхээр, хэмээн Сталин эхлэв. -Нөхдүүд ухаалаг санаанууд гаргаж, чухал чухал санал тавьлаа гэж бодож байна. Энд гарсан санаа, саналуудыг авч үзэж, Үндсэн хуулийн эцэслэсэн төсөлд оруулах редакцийн комиссыг сонгох хэрэгтэй гэж бодож байна. Тэгээд бид эцэслэсэн төслийг зөвлөлтийн бүх ард түмнээр хэлэлцүүлнэ. Татгалзах зүйлгүй юү?

Татгалзах зүйл байсангүй.

Редакцийн комиссын даргаар нөхөр Сталиныг сонгожээ.

Үндсэн хуулийн комиссын 30 гишүүнээс буудан алуулсан байдал:

1937 онд-Голодед, Енукизе, Сулимов;

1938 онд-Айтаков, Бухарин, Ербанов, Икрамов, Крыленко, Мусабекков, Рахимбаев, Уншлихт, Хожаев;

1939 онд Акулов, Радек, Чубарь;

1940 онд-Бубнов.

Червяков, Любченко хоёр амиа хорложээ.

Панас Любченко өөрийгөө буудахын өмнө эрүү шүүлт, тарчилгаанаас ангижруулахын тулд эхнэрээ буудан хороожээ.

Иван Григорьевич Оржоникизетэй Рязановын тухай ярихаасаа түдгэлзжээ. Тэрээр төмөрлөгийн асуудлыг эрхэлдэггүй учраас албан шалтаг олдсонгүй, тэгэхээр албан бусаар ярих уу? Яах гэж? Будягин яршигтай явдал тохиосон Рязановыг тэгтлээ өрөвдөөгүй. Мэдлэгтэй, чадварлаг инженер, сайн зохион байгуулагч, харин хүний хувьд бол нэг л биш, Сашагийн асуудлаар хулчгар зан гаргасан, Сталин өөрт нь талтай байгаад ташууран, сөгдөх нь халаг долдогононо, түүний талтай байх нь яаж эргэдгийг мэдэхгүй, одоо мэдэж авах байлгүй дээ.

түүнээс гадна Будягин Оржоникизетэй яг илэн далангүй ярилцахуйц харилцаа ч байхгүй. Хувийн талаас гэвэл хоюулаа Кировтой нөхөрлөдөг нь л хуучин тэднийг холбож байсан. Одоо Киров байхгүй. Түүгээр барахгүй Будягин Березиний сэрэмжлүүлгийг түүнд уламжилснаас болж Кировын үхэл тэднийг хөндийрүүлсэн. Кировын амь насны тухай яригдаж байгааг Будягин өөрөө ч тэр үедээ ойлгоогүй юм чинь Оржоникизе тэр сэрэмжлүүлгийг дутуу үнэлсэн байж мэднэ. Тэгвэл одоо яагаад Оржоникизе аж ахуйн боловсон хүчнийг яргалж байгааг эсэргүүцэхгүй байна? Одоогоор үй олныг хамраагүй ч гэсэн яваандаа хамрах төлөвтэй байна, үйлдвэр, заводын дарга, инженерүүдэд утга учиргүй ял тулган мэр сэр баривчилсаар байгаа. Зарим нэг тохиолдолд Серго эсэргүүцдэг гэх яриа бий, гэвч ДЯАК-аас аж ахуйн хэрэг явдалд хутгалдахыг шийдвэртэй таслан зогсоох хэрэгтэй шүү дээ.

Өчигдөрийн бүгд хурал, Оржоникизе яахаараа Авель Енукизег бутниргэхийг зөвшөөрдөг байна? Идэр залуугаасаа мэддэг, жинхэнэ коммунист гэж мэддэг сайн найзыгаа, ёстой хиргүй үнэнч шударга хүнийг шүү. Енукизегийн үнэнийг бичсэн товхимолоос болж Сталин түүнтэй тооцоо хийж байгааг ойлгохын цаагуур ойлгож байгаа.

Тэгсэн мөртлөө Енукизег өмөөрч юм хэлсэнгүй. Шууд босоод л “Коба! Авель итгэлийг чинь биелүүлээгүй гэж чи үзэж байна. Тэгвэл түүнийг халаад Тифлис рүү явуулчих, манай намд 30 жил үнэнч шудрагаар зүтгэлээ, тэнд амар жимэр аж төрөг” гээд хэл-чихэж болох шүү дээ. Авелийг өмөөрөхөөс айсан юм бол, үгүйдээн, ямар ч гэм буруугүй, зөвхөн Енукизегийн хэрэгт хуйвалдааны шинж оруулах үүднээс устгуулж буй жирийн хүмүүсийг, Кремлийн тэр золгүй нарийн бичгийн дарга, цэвэрлэгч, хаалгач, нярав гээд ерөөсөө тохиолдлын хүмүүсийг өмөөрдөг байгаа даа. “Тусгүй ээ, Коба, муухай...” Хэлээгүй, эсэргүүцээгүй, өмөөрөөгүй.

Рязанов Иван Григорьевичийг хилийн чанадад байсаар улс орноосоо тасарсан гэж үздэг нь эндүүрэл байжээ. Харин Рязанов өөрөө заводынхаа ашиг сонирхлоор явцуурч, улс оронд бүрэлдүүлж буй тогтолцоонд өдөр өдрөөр, цаг цагаар зохицон аялдан дагасаар аажимдаа улс төрч байхаа больж, улс төрийн биеэ даасан айгаар сэтгэхийн оронд зөвхөн өгөгдсөн айгаар сэтгэж, эргэн тойрныхоо хэрэг явдлыг анзаарах хүсэлгүй болжээ.

Будягин гурван хэл чөлөөтэй эзэмшсэн болохоор тун өргөн мэдээлэл авна. Хувь ерөөлөөрөө ч, хийсэн сургуулиараа ч техникийн боловсролтой тэрбээр орчин үеийн шинжлэх ухааны асуудлуудыг мэднэ. Оржоникизе Будягиныг үнэлдгийн хувьд АКГ-таа шинжлэх ухааны ажил, түүний дотор батлан хамгаалах салбарын аж үйлдвэрийн ажлыг даалган эрхлүүлжээ. Сталин үүнийг эс таалсан байж магадгүй.

түүний сүүлчийн нэг жишээ: Сарын өмнө, зургадугаар сарын 14-нд Сталин, Молотов, Ворошилов, Оржоникизе нар их бууны төрлийн шинэ маягийн зэвсэгтэй танилцжээ. Энэ үзлэгт Иван Григорьевичийг оролцуулах ёстой агал урьсангүй. Тэр ч байтугай түүнд мэдээлсэнгүй. Оржоникизе “Сэтгэл хангалуун байцгаана лээ” хэмээсэн нь юу ч хэлээгүйтэй адил.

Энэ бол доромжлол. Ийнхүү жижигрүүлж доромжилсон нь түүний нэр хүндийг цэргийнхний өмнө унагасан хэрэг: Намын удирдлагад тоогдохгүй, яамны нэг түшмэл төдий л хүн, ийм хүн армийг шинэчлэн зэвсэглэх үү, цэргийн аж үйлдвэрийг бүтээн босгох уу?!

Тэр яах ёстой вэ, ямар хариу байх вэ? Гомдол мэдүүлэх үү? хэнд? Сталинд уу? Бүдүүлгээр загнуулах гэж үү? Огцрох уу? Намд огцрох ёс алга. Үүнийг намын чиг шугамтай санал нийлэхгүй буйн илрэл гэж дүгнэж мэднэ, Сталин яг л тэгж зарлана, тэгээд мань хүнийг, Будягинийг “эцсийн эцэст жинхэнэ нүүр царайгаа нээсэн” ажил боогдуулагч, холбилогч хэмээн цоллоно. Үзлэгт оролцохыг уриагүй нь Сталин түүнийг чухамхүү тийм алхам руу түлхсэн хэрэг юм болов уу?!

Ямар гарц байна вэ?

Өнөөдөр өглөөний арван цагт Тухачевскийг хэсэг ажилтных нь хамт хүлээн авна. Үзлэг дээр байгаагүйгээ тэдэнд юу гэж тайлбарлах вэ? “Уриагүй” гэх үү? Үгүй ээ, тэгж хариулж болохгүй, гоморхсон, арчаагүй аяс сонсдоно. “Чадсангүй”, товчхон хайнгадуу “чадсангүй” гэж болох. Гэвч Тухачевский хүмүүжил сайтай сэхээтэн хүн учраас бараг асуухгүй биз дээ.

Яг арван цагт цэргийнхэн ирцгээв: Батлан хамгаалах ардын комиссарын зэвсэглэл хариуцсан орлогч Тухачевский, Киевийн цэргийн тойргийн командлагч Якир, Белоруссийн цэргийн тойргийн командлагч Уборевич. Тухачевский энэ хоёрыг ТХ-ны Бүгд хуралд оролцсоныг далимдуулан өөртөө дэмжлэг авахаар дагуулж ирж дээ хэмээн Будягин дотроо инээмсэглэжээ. Нийлж байгаад яамыг “шахацгаах” нь. Мэдээж, ноднин зохион бүтээсэн шинэ танкны тухай л давын өмнө ярьцгаана.

Будягин Тухачевскийн арганд сэтгэл сэргэж, үзлэгийн тухай муу бодлоо толгойноосоо хөөх гэж оролдов. Якир, Уборевич хоёр ч энэ тухай хөндөхгүй биз, Тухачевский шиг учир мэдэх хүмүүс юм чинь.

Иргэний дайны алдарт жанжнууд, армийн бахархал, найдвар болсон энэ харьцангуй залуу хүмүүсийг Будягин сэтгэл хангалуун харлаа.

Тухачевский бол тэвхгэр цэгц биетэй, дунд зэргийн нуруутай, цэнхэр нүдтэй, хүдэр царайтай, цэргийн хувцас гайхам гоё зохисон сайхан эр.

Якир бол ханхгар цээжтэй, гялалзсан бор нүдтэй, шөнтгөр хамартай, жишиггүй зоригтой хүн. Харин долгионтсон хар үсэнд нь буурал суусныг үзэхүл гучин есөн насанд эртэдсэн гэлтэй.

Эцэст нь, Иероним Уборевич бол хавчдаг шилтэй, булбарай шингэн царайтай хэв шинжит

СЭХЭЭТЭН.

Тэгсэн хэрнээ өчигдөр Бүгд хурал дээр эд нар Енукизег намаас хөөхийг дэмжсэн санал өгсөн гэх нэгэн санаа толгойд нь эргэлдээд салдаггүй. Ежовын хуурамч илтгэлд итгэсэн байж болно, тэглээ ч гэсэн дээ. Саналаа өгцгөөсөн! Ежовт итгэсэндээ биш, Ежовын цаана Сталин байсан, түүнд тэд итгэх албатай, түүнд итгэхгүй байж болохгүй учраас саналаа өгцгөөсөн. Хэрэв дайн дэгдвэл яах вэ? Тэр үед ч гэсэн Сталин Ворошилов хоёрын мулгуу тушаалуудад сохроор захирагдах уу? Гэтэл тэр чинь дайнд ялагдана гэсэн үг шүү дээ.

Үгүй ээ! Тэд цэргийнхээ асуудлаар иргэний дайны үед буулт хийгээгүйн нэгэн адил буулт хийхгүй, одоо ч хийхгүй байгаа, өөрсдийнхөө чиг шугамыг хэрэгжүүлэн, армийг бэхжүүлж, түүнийг зэвсэглэж байгаа, юм мэдэхгүй удирдагчдын эсэргүүцлийг даван туулж байгаа.

Иван Григорьевич иргэний дайны фронт дээр эд нартай, ялангуяа Тухачевскийтай олонтаа уулзаж явжээ. Цаадах нь хорин таван насандаа Дорнод фронтын 1 дүгээр армийг командалж явсан. Муравьевын бослоготой нэгдээгүй, харин түүнд баривчлагдаж золтой сумны амт үзээгүй. Будягин оролцсон хэсэг большевикууд шоронг дайран эзлэж, тэнд хоригдож байсан Тухачевский, Фельдман хоёрыг чөлөөлсөн билээ. Тэр бүлгийг Варейкис толгойлж байсан боловч Тухачевский чухамхүү Будягиныг өөрийгөө аврагч хэмээнэ.

Тухачевский 5 дугаар армийг командлан, Колчак, Деникин хоёрыг бутниргэхэд аль алинд нь оролцжээ. Дашрамд дурдахад, Иван Григорьевич чухамхүү тэгэхэд Сталин Тухачевскийд жинхэнээсээ яаж ханддагийг мэдэрчээ.

Буденный Тухачевскийн тушаалыг биелүүлээгүйн улмаас Деникин Новороссийск руу амжин зайлах, Крымд шилжин байрлах, тэнд шинэ фронт байгуулах боломжтой болсон билээ. Өөрийнх нь талд Сталин, Ворошилов хоёр байсан учраас л Буденный Тухачевскийн тушаалыг зүрхэлж хэрэгсээгүй болой.

1920 онд Варшавын хаяанд бас яг тийм хэрэг болсон билээ. Сталин Ерөнхий командлалын шууд захирамжийг зөрчин, Буденныйн армийг Львовын хаяанд саатуулан барьж, тэгснээрээ Пилсудскийд Тухачевскийн армид жигүүрийн цохилт өгөх боломж олгож, манайхан ялагдал хүлээжээ. Буруутан нь Сталин байсан, Ленин хүртэл “хэн Варшав руу Львовоор дайрч явж байсан юм бэ?” гэж хэлсэн гэж байгаа. Гэтэл Ленинийг нас барсны дараагаар зуйрган түүхчид ялагдлын бурууг Тухачевскийд тохчихжээ. Үүнд Егоров “Львов-Варшав” номныхоо оронцогоор, Шапошников “Висла дээр” номонцороороо гар бие оролцоцгоосон юм. Буденный ч өөрийнхөө зөвийг идэвхтэй нотлож байжээ.

Тухачевскийг хяхаж хавчих нь даварсаар 1930 онд Улаан Армийн Төв Ордонд болсон ээлжит хуралдаан дээр Сталиныг бялдуучлагч нэг долдой “1920 оны явдлын чинь төлөө таныг дүүжлэх хэрэгтэй” гэж Тухачевскийг дайрсан билээ. Колчак, Деникинийг ялсан хүнийг, Кронштад, Антоновын бослогыг дарсан хүнийг тэр шүү дээ. 1932 онд Цэргийн академи дээр Польшийн компаний асуудлаар хийсэн хэлэлцүүлэг тэр хавчлагын оргил болжээ. Тухачевскийг гутааж, Сталиныг шагшин магтсан өрөөсгөл, зохиомол дүгнэлтүүд үнэхээр ой гутам байсан гэж тэр хэлэлцүүлэгт оролцсон хүн Будягинд ярьсан билээ. Тухачевский тэр хурал дээр байгаагүй.

Иван Григорьевич хилийн чанадаас эдгээр хэрэг явдлыг анхааралтай ажиглаж байжээ. Тэрээр Тухачевскийг ирээдүйн дайны томоохон стратегич төдийгүй, Сталинаас ялгаатай нь Германтай дайн үүснэ гэдгийг ойлгодог хүн гэж үзнэ. Хэдийгээр Тухачевскийн эсрэг хавчлага турхиралт 1932 оноос зогссон боловч Сталин, Ворошилов, Буденый гурвын зүгээс нуугдмал том аюул түүнд нүүрлэж буйг Будягин харамсан бодлогоширно.

Тухачевский бүр иргэний дайны үед Будягинд гэр бүлийнхээ түүхийг ярьсан билээ. Ядуурсан тайжийн гэр бүлээс гаралтай эцэг нь тариачин бүсгүйд сэтгэлтэй болсон юм байж. Ээж нь аавтай нь сууснаасаа хойш бичиг үсэгт тайлагдсан.

түүнийг хүүхэд ахуйд нь хийл тоглохыг зааж сургасан. Түүгээр ч барахгүй өөрөө хийл хийдэг болж. Иван Григорьевич тэгэхэд үнэхээр гайхсан: “Нээрэн, өөрөө хийл хийж байсан гэж үү?”

-“Хийж байсан” хэмээн Тухачевский инээмсэглээд, юуг нь эхлээд, юуг нь дараа нь яаж зорж хөрөөдөж хийдгийг цаасан дээр зурж үзүүлжээ.

Тухачевский итгэл үнэмшилтэй коммунист байсан уу? Тэрээр большевикуудын ялалт бүрэн тодорхой болоогүй байсан 1918 оны 4 дүгээр сард намд элсчээ. Гэхдээ Октябрийн хувьсгал Орост ямар ач холбогдолтойг ойлгосон учраас амьдралаа түүнтэй холбосон. Жинхэнэ орос хүн, бас төрөлхийн цэргийн жанжин. Оросын хүч чадлыг бэхжүүлэх явдлыг насныхаа үйл хэрэг хэмээнэ. Хүчирхэг орон гэдэг бол хүчирхэг арми. Гэтэл өөрийнх нь армийн дайчин чадвар сэтгэлийг нь түгшээнэ. Буу зэвсэг дэндүү хуучин, онгоц, танк, тээврийн болон холбооны хэрэгсэл дэндүү цөөхөн, Тухачевский Будягины адил хэд хэдэн гадаад хэлтэй. Орос бусад орноос юугаар, хэр хол хоцорсоныг тэр хоёр маш сайн мэднэ.

1928 онд Тухачевский армийг шинэчлэн зэвсэглэх асуудлаар илтгэх хуудас бичжээ. Сталин Ворошилов хоёр түүнийг шууд үгүйсгэсний улмаас тэдний харьцаа улам хурцдаж, Тэрээр өргөдөл гаргаж штабын даргын албанаас гарсны дараа Ленинградын цэргийн тойргийн командлагчаар томилогджээ.

1930 оны 1 дүгээр сард дахиад илтгэх хуудас илгээжээ. түүнийг нь бас хэрэгссэнгүй.

Сталин Ворошилов хоёр дэлхийн дайн, иргэний дайны туршлагад тулгуурлан арагшаа харж байсан бол Тухачевский цэргийн жинхэнэ суу билигтний хувьд урагшаа харж байжээ.

Гэвч армийг техникийн хувьд шинэчлэн сэргээх ёстойг эрхбиш ойлгож нэг жилийн дараа Тухачевскийн бичгийг нууцын шүүгээнээс гаргаж иржээ. Тухачевскийг шоолж, саналыг нь үгүйсгэж байсан нөгөө хүмүүс чинь тэр хөтөлбөрийн хэрэгжилтийг чухамхүү түүнд арга буюу даалгав. Тухачевскийг Батлан хамгаалах Ардын Комиссарын зэвсэглэл хариуцсан орлогчоор томилж, мань хүн ч ажилдаа шамдан орлоо.

Будягин түүнд чадах чинээгээрээ туслана.

Нэрсийг нь хамтарч гаргаж байгаад гарамгай эрдэмтэд, зохион бүтээгчдийг уг ажилд татан оролцууллаа. Хөнгөн хуягтай хурдан танк дээр үү, хүнд хуягтай, хурд багатай танк дээр үү? Тухачевский, хамгаалалт сайтай, тэгсэн мөртлөө зэгсэн хурдтай дунд гарын танк бүтээхийг

чухалчлан зорилоо. Шинээр зохион бүтээсэн танк чухамхүү тийм болж чаджээ.

Уборевич ширээн дээр буй төсөл зургийг харж,

-Ёстой сайхан машин, бүх туршилтыг давсан, одоо олноор нь үйлдвэрлэж эхлэх, хүмүүсээ сургах, танкийн сургуулилтаа жигдрүүлэх цаг нэгэнт болоод байна гэв.

Тэрээр ядарсан царайтай, хавчдаг шилнийх нь цаанаас нүд нь томорчихсон мэт харагдана. Энэ ч өчигдрийн Бүгд хуралтай л холбоотой доо гэж Будягин бодов. Уборевич бусдаасаа хол харж байгаа бололтой.

-Олноор үйлдвэрлэх ажлыг гучин найман оноор товлож байгаа гэж Будягин хэлэв.

-Энэ бол том алдаа, хүнд алдаа! хэмээн Якир сандлаа тар түрхийлгэн ухартусав. -Бид хөнгөн танк үйлдвэрлээд дасчихаж. Одоо гол юм бол сум нэвтрэхгүй хуягтай дунд гарын танк.

-Чи тавилга битгий эвдчихээрэй хэмээн Иван Григорьевич инээвхийлэв.

-Загвар бүхэн өөрийн гэсэн давуу талтай, яаж ч удаан маргасан болно, гэхдээ нэгдмэл шийдэлд хүрэх цаг болчихоод байна. Энэ танк бол хамгийн ирээдүйтэй машин, миний бодлоор бол олон жилийн ирээдүйтэй гэж Тухачевский өгүүлэв.

Хөнгөн, хүнд танкны загварыг аль алийг нь шүүн хэлэлцэв. Дахиад туршилт шаардлагатай учраас энэ тухайд санал зөрөлдсөн боловч дунд гарын танкны тухайд энэ бол хэрэгтэй танк яг мөн, үйлдвэрлэх ажлыг удаашруулж болохгүй гэдэг дээр санал бүрэн нийлцгээжээ.

Иван Григорьевич уг асуудлыг Ардын Комиссарын газрын тун ойрхны коллегийн хуралд оруулахаар амлав.

Намын удирдагчид их бууны төрлийн шинэ зэвсэгтэй танилцсан тухай хэн ч яриа сэдсэнгүй, уул нь Тухачевский тэр үзлэгт гарцаагүй оролцсон байх ёстой. Эсвэл Тухачевскийг бас уриагүй юм болов уу. Ворошилов танилцуулахад л Сталинд бүрэн хангалттай байж болох л доо.

Цэргийнхэн явж, Будягин урамгүй бодолдоо дахиад л автлаа... Ноднингийн яриаг Сталин хэзээ ч өршөөхгүй. Ямар ч атугай, сталинч бодлогын чиглэл Зөвлөлт Холбоот Улсын хувьд ч, дэлхийн коммунист хөдөлгөөний хувьд ч эмгэнэм хор хөнөөлтэй гэдэгт Иван Григорьевич бүрэн итгэж байгаа. Сталины түрүүчийн бодлого эхнээсээ адгаа хүртэл алдаатай байсан лугаа адил Гитлерийг засгийн эрхэнд гарснаас алдаатай дүгнэлт хийсэн. Бүх таамаг буруудсан, стратеги нь харалган, тактик нь болхи болж таарсан.

Хориод онд Германд фашизм дэвэрсэн нь бүхий л бодлогоо шийдвэртэй өөрчлөхийг шаардсан. Ажилчин ангийн нэгдмэл фронт байгуулж, социал-демократ намуудтай ойртвол зохих байлаа. Фашист аюул нүүрлээд ирэхээр социал-демакратууд фашизмын эсрэг хатуу байр суурь баримтлах болсон шүү дээ.

Бодлогын тийм өөрчлөлт хийгдээгүй.

Харин ч болвоос Сталин 1929 оноос Коминтернд тэргүүлэх үүр-гээ бататгаснаар социал-демакрат үзэл бол хувьсгалт пролетарийн гол дайсан мөн, “фашизмын нэг онцгой хэлбэр нь... социал-фашизм мөн”, “заналт дайсных нь хувьд социал-демократын эсрэг, ялангуяа түүний “зүүн” жигүүрийн эсрэг хийх тэмцлийг эрс эрчимжүүлэх” зорилт коммунист намуудад тулгарч байна гэж тунхаглажээ. түүнтэй аливаа хэлхээ холбоог таслаж, түүний “социал-фашист” мөн чанарыг уудлан илчлэх хэрэгтэй...

Энэ бодлогогүй хийрхэл Гитлер засгийн эрхэнд гарахыг эрс хөнгөвчилсөн байна.

1928 онд нацистуудын төлөө 810 мянган сонгогч санал өгсөн бол Германы коммунистууд социал-демократуудыг улайран муучлах болсноор 1930 оны 9 дүгээр сарын 10-нд нацистуудын төлөө 6 сая 400 мянга буюу найм дахин илүү санал өгчээ.

Гитлерийн хирдхийм амжилтаас улбаалан Сталин Коминтерний бодлогоо эрхбиш өөрчлөх ёстой гэж бодмоор. Гэтэл Сталины бодлоор бол нацизмын нэр дээшилж байгаа нь хөдөлмөрчин олон түмэн парламентийн горьдлогоосоо хагацаж, хувьсгалт лагерьт зайлшгүй шилжиж ирэхийг л гагцхүү гэрчилж байгаа юм гэнэ. Үүний учир социал-демократыг бутниргэх явдал гол зорилт болсон хэвээр байна.

Коминтерний хагалан бутаргах бодлого германы ажилчны хөдөлгөөний эв нэгдлийг бусниулан доройтуулж, Гитлерийг чанга-руулжээ. Сталины бодлогын үр дүн илэрхий: 1933 оны 1 дүгээр сард нацистууд 11,7 сая, социал-демократууд 7,2 сая, коммунистууд 6 сая орчим санал тус тус авсан билээ. Тэгэхэд коммунистууд, социал-демократууд нийлж фашизмын эсрэг нэгдмэл фронт байгуулсан сан бол байдлыг аврахад оройтохгүй сэн. Гэвч тэгээгүй учраас фашистууд засгийн эрхэнд гарчээ.

Иван Григорьевич тэр үед Лондонд байхдаа сониноо нээхдээ яаж айдаг байснаа санаж байна... Сонин тэр чигээрээ Гитлер, түүний хамтран зүтгэгчид, түүний зэвсэгт залуучуудаар дүүрчихсэн байдаг сан. Гитлер үг хэлж байна, парад хүлээн авч байна, Гитлер Герингтэй, Геббельстэй, Риббептронтой, залуучуудтай, ажилчдын өмнө гэх мэт. Тэг тэгсээр эцэст нь,

хамгийн аймшигтай зураг: Германы ерөнхийлөгч фельдмаршал Гинденбург рейхийн канцлерын албанд орсонтой нь холбогдуулан Гитлерт баяр хүргэж гар барьж байна... Энгийн хувцастай, бүрх малгайгаа барьсан Гитлер ёсорхуу инээмсэглээд Гинденбургийн өмнө мэхийчихэж, цэрэг хувцастай, прусс дуулгатай, сэлэм агссан цаадах нь Германы шинэ удирдагчийг харамсаж эмээсэн царайтай хараад зогсож байна.

Сталин энэ аймшигт ялагдлаа “Фашистын диктатурыг ил тогтоосон явдал олон түмний аливаа ардчилсан горьдлогыг үгүй хийж, олон түмнийг социал-демократын нөлөөнөөс чөлөөлөн, Герман пролетарийн хувьсгал руу урагшлах хурдацыг түргэтгэж байна” хэмээсэн арчаагүй үгээр цайруулжээ.

Фашистуудын ялалт түүнийг сэнхрүүлсэнгүй, тэр ч байтугай гайхшийг нь ч төрүүлсэнгүй. Тэрээр нацистуудыг Англи, Францын эсрэг хүч, социал-демократуудыг тэдний талынхан гэж зөрүүдлэн зүтгэсээр байлаа. Тэгэхээр Германд үндэсэрхэг социалистууд ялсан нь өрнөдийн эсрэг хүчний Зөвлөлтөд ашигтай ялалт. Харин социал-демократууд ялсан бол өрнөдийн талын хүчний Зөвлөлтөд ашиггүй ялалт болох байсан.

Ингээд бодоход Сталин ноднин Будягинд: “Англи, Францад сөр-гүүлэн тавих үүднээс бид Германыг хүчирхэг байлгахыг сонирхож байна” гэж хэлсэн нь санамсаргүй үг биш байх нь. Улс төрийн чиг шугамынх нь мөн чанар энэ. Бусад бүх юм-донгосолт.

Би, Будягин гэдэг хүн одоо яах вэ?.. Зөвлөлтийн заналт дайсан, соёл иргэншилт бүх дэлхийн заналт дайсан-фашизм яаж өсч хөгжиж, яаж бэхжиж байгааг амар тайван хараад сууж байх уу? Эсвэл энэ бодлогын эсрэг дуу хоолойгоо гаргах уу?..

Иван Григорьевич оройтдог янзаараа оройтож ирэхэд Лена, Владлен хоёр хэдийн унтчихсан, Ашхен Степановна өрөөндөө ажиллаж байв. Авгай нь ТХ-ны олон улсын асуудал хариуцсан лекторын хувьд ярих зүйлээ маш нарийн бэлтгэж, өөрийнх нь хэлдэгээр бол албаны утгагүй хоосон цэцэрхэлийг хүний хэлэнд хөрвүүлнэ.

Иван Григорьевич түүний жижигхэн ширээний хажуу дахь зөөлөн сандалд лагхийтэл суулаа.

-Юм идэх үү? гэж Ашхен Степановна асуув.

-Үгүй ээ, буфетнээс юмхан гоочилсон.

Ашхен Степановна ширээ, ширээн дээрх ном, цаасаа ширвэн харснаа,

-Өөр ажилд шилжих хэрэгтэй байна гэж эрсхэн өгүүлэв.

-Тодорхой яривал?

-Түүхийн ч юм уу, археологийн ч юм уу, ямар нэг музейд. Арга барвал Хувьсгалын музей. Эсвэл эрүүлийг хамгаалах салбарт ч юм уу...

-Хонгор минь, анагаахыг чи алин хэзээний мартчихсан хэмээн Иван Григорьевич инээв.

-Тэр ч тийм. Би захиргааны ажлыг л ярьж байгаа юм. Энэнээс л салж байвал ямар ч ажил хамаа алга...

Тэрээр ширээгээ дахин хямсайж хараад, Сталины “Ленинизмын асуудлууд”-ыг авлаа.

-Хар даа, энэ жилийн хэвлэл, 2 сая 111 мянган хувь хэвлэсэн байна. Мөдхөн Библи судар шиг, ганц энэ номтой л үлдэх нь. Гэтэл Владимир Ильичийн зохиолуудыг зуу мянгахан хувь хэвлэж байна. Бас түүнээс иш татаж болохоо байсан. Сталины иш татсаныг л давтаж болно, ер нь тэгж давгахын ч хэрэггүй, шууд л Сталинаас өөрөөс нь иш татсан дээр. Тэгэхдээ задлаж тайлбарлаж болохгүй. Тэрээр өөрөө л өөрийгөө тайлбарлана. Иван, ажиллах аргагүй болчихоод байна, нээрэн шүү. Лекц уншихаасаа урьдаар ярих юмныхаа товчлолыг биш, бүрэн сэдвийг суртал ухуулгын газарт үзүүлэх ёстой, түүнийг нэг муу бичиг үсэгт хагас тайлагдсан хулчгар тоть шалгаж байгаа нь тэр гэж миний хамаг санааг сараачиж баллаад, сонинд гарсан юмыг яг гарсан чигээр нь болгоод үлдээчихнэ, тэр утга учиргүй, тэр худал хуурмаг, тэр хараал зүхлийг нь би уншиж байх ёстой болчихоод байна. Тэр бүхнийг яг цаасаа харж уншина. Тэгвэл миний хэрэг юу байна? Цаасан дээрхийг хэн ч уншиж чадна шүү дээ. Би тодорхой баримтыг хүртэл үнэлж дүгнэх эрх байхгүй, уул нь миний сэдэв чинь олон улсын байдал, олон улсын байдал өдөр болгон өөрчлөгдөж байгаа шүү дээ... Гэтэл би их л сайндаа сарын өмнөх явдлыг лекцэн дээр ярьж байна. Өчигдөр, өнөөдөр болсон явдлын тухайд “нөхөр Сталины зөв зүйтэй урьдчилан харсанчлан”, “нөхөр Сталины яг урьдчилан хэлсэнчлэн”, “нөхөр Сталины энэ тухай зөв зүйтэй хэлсэнчлэн” гэж заавал ярих ёстой. Харин мань хүний урьдчилан харсан, урьдчилан хэлсэн, ярьсан юм нь болсон явдлын яг эсрэг байхыг яана. Би намын идэвхтэнд яриа хийж байгаа юм чинь эрхбиш бага ч болохноо мэдлэгтэй хүмүүс, тэд намайг эсвэл хоосон цээжлэхээс цаашгүй мангуу толгой, эсвэл ичих нүүргүй худалч амьтан гэж илт бодож байна. Гэтэл би намд их ч үгүй, бага ч үгүй хорин таван жил боллоо.

-Хорин зургаа гэж Иван Григорьевич залруулав. -Чи бид хоёр танилцаад хорин таван жил болж байна, энэ бол намын гишүүний хугацаа биш, тийм учраас битгий залуурх.

Хүүхэн нь инээд алдав.

-Нээрэн, чиний зөв хэмээн Тэрээр царай нь дахин бүүдийв. -Иван, чи Павел Родионовыг санаж байна уу, бас Лондонд байгаагүй юу? Би чамд бүр ярихгүй гэж бодож байсан юм. Казаньд очлоо, яриа хийх юм болсон чинь эхний эгнээнд хэн сууж байсан гэж санана? Паша. Над руу инээмсэглэж байна, мөн ч олон жил уулзалдаагүй дээ. Миний төлөөнөөс мань хүн ичиж байгаа нь илт. Лекцний дараа над дээр ирээгүй, миний хэн болох нь түүнд тэртэй тэргүй тодорхой гэдгийг над ойлгуулсан хэрэг л дээ... Би буудалдаа ирээд шөнөжин унтаж чадаагүй. Тэгээд би цаашдаа ингэж байж чадахгүйгээ мэдэрсэн.

Родионовыг Иван Григорьевич санахын цаагуур санаж байгаа, нэг үе түүнийг Ашхентай хүртэл хардаж явсан удаатай. Пашка бас анагаахын салбарт сурдаг, хичээл тарахаар Ашхенийг гэрт нь дөхүүлж өгнө. Хаа нэг ч биш, өдөр болгон түүнээс зүүгдчихнэ. Тэр хоёр цуг инээж хөхрөөд явж байхыг Иван Григорьевич нэг удаа харсан. Ашхен тэгэхэд дөнгөж хорин нэгтэй, дэрс шиг нарийхан охин. Гэвч дараа нь тэр хоёр гэрлэж, Пашкагийн үдлэг хар аяндаа төгссөн болой.

Ашхен Бакугийн баян армяны хүүхэд, хувьсгалын мөр хөөж большевикуудтай нийлээд, эцэг эхтэйгээ тангараг тасарчээ. Яахаас ч буцахгүй, аймшиггүй тэр хүүхэн хувьсгалын хэрэгт ёстой номоор нь зүтгэжээ. Ухаантай, гурван ч хэл мэднэ, Иван Григорьевичийг тэр л чирч байж хэлтэй болгосон, тэд нар хоорондоо нэг өдөр германаар, нэг өдөр францаар, нэг өдөр англиар ярилцдаг байжээ.

Литвиновтой цуг ажиллаж явсан, хориотой ном Орост оруулж явсан, иргэний дайнд армийн улс төрийн хэлтсийн даргаар оролцож явсан хүн. Тэгэхэд Ашхенд балнад тусч их зовсон, Ленагаа Мотовилиха руу, Иваны эцэг эх рүү явуулсан. Тэр өвчнөөс арайхийж аварсан, ёстой арайхийж... Товчдоо, нууц большевик ажилтны ердийн л намтар. Одоо лекц унших гэж хүрэхгүй газаргүй савчиж явна, гэвч нэгэнт хүлцэхийн аргагүй болсон бол үнэхээр өөр ажил хайх хэрэгтэй.

-Литвинов руу шилжиж болох юм биш үү, чи гадаад хэлтэй юм чинь?

-Үгүй чиш! гэж хүүхэн эрс татгалзав. -Э н э бодлогыг би заяа нь хэрэгжүүлэхгүй. Литвинов идэвхгүй, НӨГӨӨ хүн хааш нь хөтлөөд байгааг би харж байна.

-Долдугаар сарын 25-д Коминтерний ҮШ конгресс нээгдэнэ. Би илтгэх хуудсаа явуулах ёстой гэж бодож байна гэж Иван Григорьевич өгүүлэв.

Ашхен түүн рүү цочир эргэв. Нүд нь дүрлийчихэж.

-Тэр чинь чиний толгойд хүрнэ дээ!

-Ашхен, ингэж эрэгцүүлэх юм бол ч...

Авгай нь түүний үгийг тасдав:

-Бүгд ингэж бодож байгаа. Тэр нь ч зөв. Алдах цагаа алдчихсан шүү, хонгор минь! Та нар цөмөөрөө хэн нэгнийг тухайлбал, Троцкий, Зиновьев, Каменев, Бухарин энэ тэрийг засгийн эрхэнд яаж гаргахгүй байх вэ л гээд бодоод байсан. Гагцхүү мань хүн л засгийг ө ө р ө ө яаж авах вэ гэдгийг бодсон. Тэгээд ч авсан. Одоо түүний мөр дээр гарч ирсэн хэнийг ч болов устгана. түүний мөр дээр байсан хүмүүс сүйрэх нь тодорхой, чи үүнийг мэдэж байгаа. Ингэхэд, өчигдөр Тер-Ваганянийг баривчилчихсан.

Тер-Ваганян бас Бакугийнх, Ашхен тэдний гэрийнхнийг мэдэх билээ.

-Тэр чинь троцкийчуудын нэг шүү дээ гэж Иван Григорьевич хэлэв.

-Асан! Иван, асан гэдгийг битгий март! Тэр чинь аль 1928 онд сөрөг хүчнээс хөндийрсөн, намын гишүүнчлэлийг нь ч тэгэхэд сэргээсэн. Чин санаанаасаа хөндийрсөн, би сайн мэднэ. Гэвч түүнд энэ бол огт падгүй, түүний мөр дээр нэг л удаа тээглэсэн бол устгуулж таарна. Бүгдийг нь устгана, чи харна аа гайгүй. Харин чи бол ямар ч сөрөг хүчинд оролцож байгаагүй, энэ тухайд цэв цэвэрхэн намтартай. Иймээс өөрөө өөртөө нүх ухах хэрэггүй. Одоо түүнийг яах ч арга байхгүй. Хүлээх хэрэгтэй.

-Юуг?

-түүний бодлогын сүйрлийг.

-Тэр үед чинь оройтчихсон байна биз.

-Үгүй ээ. Намын боловсон хүчнүүд өөрснийгөө авч үлдсэн байх юм бол оройтохгүй. Тэгвэл түүний гараас эрх мэдлийг салгаж болно. Гагцхүү өөрснийгөө л авч үлдэх хэрэгтэй. Өөрсдийгөө бас хүүхдүүдээ. Тийм ээ, хүүхдүүдээ. Хүмүүс үр хүүхдийнхээ хувь заяаны тухай бодож байгаад гэмтэй ч юм байхгүй, намын эсрэг ч юм байхгүй.

Иван Григорьевич бослоо.

-Ашхен, үнэнийг хэлэхэд, чамаас ийм юм сонсоно чинээ санасангүй шүү.

Хүүхэн бас босч,

-Владлен естэй, Лена хөл хүнд болсныг чи өчигдөр мэдэж авсан, үүнийг, чамд заавал сануулах болж байна, Иван, хэлсэн үгээ сайн бод гэж эрс шийдэмгий хэлэв.

Тэгээд өрөөнөөс гарлаа.

Ажлынх нь өрөөнд түүний хөлийн чимээ гарч, буйдан дэлгэж байгааг Иван Григорьевич мэдрэв.

Тэрээр жуумалзав. Ашхен нөхөртөө сэтгэл дундуур байх буюу яриагаа үргэлжлүүлэх дургүй байвал түүний ажлын өрөөнд ор засч өгдөг эртний зуршилтай билээ.

Тэрээр өрөөндөө ороод авгайгаа мөрөөр нь тэврэв.

-Битгий уурла!

-Би уурлаагүй ээ. Харин чиний хүүхдүүдийн тухай, ирээдүйн зээ хүү буюу зээ охины тухай чамд сануулья. Тэднийг ийм бодлогогүй золиосолж болохгүй!

Иван Григорьевич ганцаараа үлдэв.

Эдүгээ олон хүн айж байгаа шиг Ашхен ч айж байна. Харин өөрөө айх эрхтэй билүү? Тийм ээ, хэцүү цаг, хүнд цаг ирж. Гэвч мань хүн өөрийнхөө үүргийг биелүүлэх ёстой, тэгж гэмээ нь энэ нь бусдыг өөрийнхөө үүргийг биелүүлэхэд албадлага болно. Одоо, сталинч стратеги ийм илэрхий нурчихаад байхад, энэ стратегийн уршгаар Гитлер засгийн эрхийг авчихаад байхад хэлэх юмаа эрс шулуухан хэлэхгүй юм бол хэзээ хэлэхэв. Эс тэгвээс Гитлер улам хүчирхэгжин Сталин буулт хийхээс өөр аргагүй болно, тэр буултных нь зах хязгаарыг хэн мэдэх билээ?!

Иван Григорьевич Сталинтай уулзвал ямар нэг үр дүн гарах байх гэж найджээ. Сталин түүний байр суурийг үгүйсгэдгийг Тэрээр мэднэ, гэхдээ энэ бол түүний үгэнд ор тас орохгүй

гэсэн үг хараахан биш, Сталин хүний санааг авчихаад эзнийг нь хожим устгах явдал бишгүй бий, эзнийг нь үгүй хийчихээд санааг нь зээлдэх явдал бүр ч элбэг. Тавдугаар сарын 2-нд Францтай харилцан туслах гэрээнд гарын үсэг зурсан, 16-нд мөн тийм гэрээ Чехословактай байгууллаа. Өнгөнөөс үзвэл Гитлерийг чадсан хэрэг. Энэ стратеги үү, тактик уу? Ямар ч атугай, үүнийг бататгах хэрэгтэй, энэ замаар урагшлах хэрэгтэй.

Сталин Коминтерний ҮII конгресс дээр нэгдмэл фронтын бодлого зарлах уу, ажилчны хөдөлгөөний хагарлыг зогсоох уу, тэгж фашизмын замд хаалт тавих уу?

Байдлыг харвал тэгэх гээд л байх шиг. Өөр зам алга. Суртал ухуулгын бүх машин Гитлерийн эсрэг ажиллаж байна. Тэглээ ч гэсэн энэ стратеги уу, тактик уу?

Будягин ноднин Сталинтай уузсаныхаа дараа ТХ-нд явуулахаар илтгэх хуудас бичжээ. түүнийгээ явуулах уу, яахав гэж бүтэн жил тээнэгэлзжээ. Сталинтай яриад ямар ч нэмэргүй гэдгийг тэр уулзалт харуулсан. Бас Ашхен ч илтгэх хуудсыг явуулж болохгүй гэж үзэж байгаа.

Гэвч ЗСБНХУ өнгөрсөн оны 9 дүгээр сард Үндэстний холбоо-ноос Герман, Япон хоёрыг гарсны дараа тэр байгууллагад элссэн, Франц, Чехословактай холбоотны гэрээ байгуулсан зэргийг харгалзан Будягин илтгэх хуудсаа ТХ-нд явуулахаар шийджээ. ҮII конгресс нэгдсэн фронтын бодлогыг боловсруулж гаргах ёстой.

Иван Григорьевич илтгэх хуудсаа дахин гүйлгэж харлаа. Тэрээр Сталины уурыг шатааж магадгүй зарим нэг хурц зүйлийг аль хэдийн хассан билээ. Бүхэлдээ одоо ч хурц байна, гэхдээ шүүмжлэлийн гол бай нь Германы коммунист нам. Бас улс орны хувьд гол аюул Германаас гарна гэдгийг цохон хэлсэн. Сталин үүнийг юу гэж үзэхийг ойлгож байгаа хэдий ч.

Профессор Марасевич хүүхдүүдээ насанд хүрсэн хүмүүс, орчин үеийн хүмүүс, өвгөрсөн өөрийг нь бодвол цаг үеэ илүү ойлгох юм чинь өөрсдөө толгой мэдэн аж төрцгөөг гэж бодох тул охиныхоо шинэ хүнтэй сууж байгааг анхныхтай нь адил төдий л эс хайхарчээ.

Харин Вадим хилэгнэхийн цаагуур юм болж. Яана гэнэв? Гадаадын хүнтэй суух ий?! Парис явах ий?! Биеийн байцаалтын “Хилийн чанадад төрөл төрөгсөд бий эсэх?” гэсэн асуултад үүнээс хойш “Бий” гэж бичиж байх ёстой болох нь. Аль нэгэн холын хамаатан биш, зүгээр ч үгүй, төрсөн дүү нь шүү. хүнтэй суугаад өөрөө яваад өгсөн. хэнтэй суусан гээч! Зөвлөлтийн эсрэг үзэлтэнтэй! Тэр муу Шарль зөвлөлтийн эсрэг үзэлтэн юм чинь.

Парисын хэвлэлд нийтлүүлсэн түүний гүтгэлгийн чанартай сурвалжлагын талаар “Известия”-д хоёр ч няцаалт гарчихаад байгаа. Ирэх оны 2 дугаар сард Францын парламент Франц-Зөвлөлтийн гэрээг батламжлах ёстой учраас л түүнийг Москвагаас хөөж явуулаагүй. Харин одоо өөрөө буцаж байна. Дүүгийнх нь энэ муу нөхөр шүү юм Зөвлөлт орон руу ямар муухай угаадас цацахыг төсөөлж цөхөх юм алга. түүний хүргэн дүү шүү юм... Өөрийнх нь, Вадим Марасевичийн хүргэн дүү, ганц дүүгийнх нь нөхөр Парисын хэвлэлд зөвлөлтийн эсрэг хорон санаатай өгүүлэл нийтлүүлж байх болох нь. Ээ дээ, бас!

Вадим дүүгээ бүр дунд сургуульд байхад нь, элдэв новшоор гангарах дуртай, ресторан хэсүүчилдэг, нийгмийн идэвхгүй гэж бухимдан засч хүмүүжүүлэх гэж оролдсон. Дараа нь тэр байдалтай эвлэрсэн. Өөр цаг ирж, шинэ байдалд зохицон байраа олж, хайр хүндлэл нэмэгдээгүй ч нэг дор аж төрөх боломжтой болсон.

Тэдний гэр бүл тохиосон аз золоор гагнагдан, ийнхүү амар жимэр аж төрлөө тордоод хүн бүхэн хувь нэмрээ оруулах ёстой, харин гэртээ гай тарих юм хэн ч хийх ёсгүй, ёстой хориотой зүйл тэр, хэцүү бүхнийг их үзсэн болохоор тэдний амьдралын болзол чухамдаа энэ. Гэтэл Вика энэ болзлыг зөрчиж, ар худрагаар нь тавилаа, өрх гэрийг нураалаа, түүний хувь заяа, түүний ирээдүйг сүйтгэлээ.

Эцэгт нь бол мэдээж, юу ч болохгүй, амьдралаа нэгэнт зохиож чадсан хүн, түүний цол хэргэм, цалин цавуу, шагнал соёрхолыг хэн ч булааж авахгүй.

Тэгвэл, Вадимд өөрт нь ямар байх вэ? Хичнээн амжилттай сайхан эхлэж байгаа билээ. түүний өгүүллийг ямар ч сэтгүүл дуртайяа нийтлэнэ, түүнийг хамгийн зарчимч, хамгийн эвлэршгүй шүүмжлэгч гэж хүлээн зөвшөөрсөн, нэмэрт нь бараг л хамгийн мундаг уран илтгэгч гэж тооцогдож байгаа, аливаа хэлэлцүүлэг болгон дээр үг хэлнэ... түүний ивээгчид, Ермилов, Кирпотин хоёр одоо юу гэх бол? Кирпотин өөрт нь яаж итгэдэг сэн билээ дээ? Зохиолчдын их хурлаар Кирпотинд ч тусласан, редакцийн комиссын гишүүн Владимир Владимирович Ермиловт ч тусласан. Вадим түүний даалгавраар, хүүхдийн утга зохиолын асуудлаар илтгэсэн Маршак, залуу зохиолчдын асуудлаар илтгэсэн Ставский, хэвлэлийн газруудаас эхлэн бичигчидтэй ажиллах асуудлаар илтгэсэн Кузьма Горбунов энэ тэрд илтгэлийнх нь таталбар тэмдэглэлийг хянуулахаар аваачиж өгч байсан, тэр ч байтугай, Николай Николаевич Бухарин, бас Карл Радек хоёр дээр очсон, гэхдээ зүгээр зарлагаар биш,

редакцийн комиссын ажилтны хувьд очиж, хэлсэн үгийнхээ санааг гажуудуулахгүйгээр таталбар тэмдэглэлийг засч болно гэдгийг мэдэгдсэн. Владимир Владимирович Ермилов ажлыг нь үнэлж хангалуун байсныг яана.

Одоо энэ бүхэн нурах нь. Дүү нь гэж нэг рестораны зайдан хүүхэн гадаадын нэг юмтай орооцолдчихоод, хилийн чанад руу явчихсан гэж тайлбарлаж явах албатай болох нь.

Тэрээр өрөөн дотроо холхиж, шүд нь өвдсөн мэт гаслан байв. Завхай эм, шулмын завхай эм! Эцэст нь тэсч чадалгүй Викагийн өрөө рүү дайрч оржээ.

-Голын хийгээ дарж үз гэж Вика тайван хэлэв. -Эм шинжтэй гэдэг нь! Чи энд ямар хамаа байна? Ах уу? Тэгээд юу гэж? Тэр чинь юу юм бэ? Тэр бол юу ч биш. Би нялх охин биш. Би гэрээсээ зайлаагүй. Би нөхрөөсөө зайлж өөр хүн дээр очиж байна. Би Уран барилгачаас зайлсан, чи ойлгож байна уу?! Яагаад хүүхнээ харж хандахгүй, өөр хүн рүү явуулчихаж байна? гэж түүнээс л асууна биз.

-Чи түүгээр овоглодоггүй, манай овгоор овоглож байгаа гэж Вадим хашгичив. -Чи яагаад түүнтэй бүртгүүлээгүй юм бэ? Яагаад гэвэл, тэр чинь албан ёсны авгайтай, чи бол авгай нь биш, нууц амраг нь, мэдэв үү, чи! Чи түүнтэй ердөө унтаж л байсан. Чи бол Марасевич, ойлгов уу?

-Би хууль бус юу хийчихээв? гэж Вика хэнэггүй асуув. -Би Шарльтай албан ёсоор бүртгүүлж, түүний овгийг авсан, хил давах албан ёсны зөвшөөрөл авсан. Би хууль зөрчиж үү?

-Чи хуулинаас илүү юм зөрчсөн, зөвлөлтийн хүний наад захын ёс зүй, наад захын үүргийг зөрчсөн. Хилийн чанад руу цөлүүлнэ гэдэг бол ял, ялын дээд хэлбэрийн нэг. Гэтэл чи өөрийнхөө зоргоор гадагшаа явж байна. Шившиг!

-Үгүй ер дөө, яасан үнэнч, шударга, ухамсартай амьтан бэ гэж Вика хямсалзав. -Хэзээнээс нааш тийм болчихоов? Чи бол хулчгар амьтан, хулчгартаа л энэ ичгүүргүй юмнуудад үйлчилж, зүтгэж яваа. Чамайг бүгдээрээ ад үзэж байгаа, Чамайг алуурчин гэцгээдэг, алуурчин, барлаг гэж байхыг нь би чихээрээ сонссон... Тийм учраас чи бүү санаа зов, надаас болж чамд муу юм ер болохгүй. Ер нь чи надад сургаал айлдахаа боль, бүр залхаж гүйцлээ! Хаалгаа цаад талаас нь хаа!

Вадим хаалга саван гарлаа. Муу новш! Янхан! Адгийн шулам! Энүүнийг гадаадынхантай сүлбэлдсэн хэргээр шоронд хийчихсэн бол ахад нь ямар олиг байх вэ, гэхдээ л дээр байх байсан. Дүү нь тийм тиймийн учир хоригдож байгаа, эсвэл цөллөгт байгаа гээд л ганцхан удаа тайлбарласан болоод л гүйцээ! Гэтэл одоо тэр муу нөхөр нь долоо хоног алгасахгүй өөрийгөө сануулах болно.

Вадим уран илтгэгчийн авьяастай учир байн байн яриа хийнэ. Хурал зөвлөлгөөн, редакцийн болон уран сайхны зөвлөл дээр лекцлэнэ, илтгэнэ, түүнээс гадна зөндөөн юм бичнэ. Лекц яриаг хэдхэн зуун хүн сонсдог бол өгүүллийг мянга түмэн хүн уншина.

Зохиолчдын тархай бутархай, бүлгэмсүү байдлыг эцэслэж, тэдний хүчийг нягтруулсан

Нэгдүгээр их хурлаас хойш зохиолчид социалист байгуулалтын сэдэв рүү, аж үйлдвэржүүлэлт, хамтралжуулалт, улс орныг өөрчлөн байгуулах сэдэв рүү хандацгаалаа. Утга зохиол эрчимтэй хөгжиж байгааг Катаевын Магнитогроскийн тухай, Эренбургийн Кузнецкийн барилга байгууламжийн тухай, М.Ильиний Сталинградын тракторын заводын тухай, Шагиняны УЦС-ын тухай, Леоновын “Сархинаг”, Алексей Толстойн “Их Петр хаан” зэрэг роман нотлож өглөө.

Тэдгээрийн олонхи нь зохиолчдын их хурлаас өмнө бичигдсэн нь үнэн, гэхдээ л их хурлын утга зохиолд үзүүлэх нөлөөллийг диалекти-кийн үүднээс авч үзэх хэрэгтэй. Их хурал чухамдаа нөхөр Сталины 1932 онд зохиолчдтой хийсэн яриа, түүний Демьян Бедный, Безыменский, Билль-Белоцерковский нарт бичсэн захидлуудаар эхэлсэн үйл явцын отго болсон юм. Чухамхүү нөхөр Сталины ярьсан зүйл, бичсэн захидлууд утга зохиол дахь намын эсрэг хөрөнгөтний хандлага, зүсэн бүрийн бүлэглэл, хэлбэрдсэн чиглэл, домоглолыг бутцохилоо. Чухам тэгэхэд, 1932 онд, нөхөр Сталин зөвлөлтийн утга зохиолыг социалист реализмын утга зохиол гэж тодорхойлсон билээ. Нөхөр Сталины эхлүүлсэн үйл явцын отго, төгс нотолгоо нь тийнхүү Зохиолчдын I их хурал болсон бөгөөд 30-аад оны эхээр утга зохиол цэцэглэн хөгжсөн нь нөхөр Сталины өгүүлэл, хэлсэн үг, ярьсан зүйлийн таатай нөлөөний ач тус даруй мөн.

Театр ч бас хөгжиж байна. Погодин, Вишневский, Корнейчук, Афиногенов, Ромашев энэ тэрийн жүжгүүд түүний нотолгоо. Гэхдээ Мейерхольд, Таиров нарын бүтээл дэх билигчлэх гоо зүйн хоцрогдол, ирээдүйчлэх болон конструктивч хандлага болгоомж төрүүлж байгаа тал бий.

Шүүмжлэгч Вадим Марасевичийн дуртай үг нь “болгоомж төрүүлж байна” гэдэг үг аж. Тэрээр уг үгийг мөд бутниргүүлэх бүтээлийн тухайд хэрэглэдэг бөгөөд, ниргэлт тохиосон цагт тэр ажилд хууль ёсоор оролцоно. Ниргүүлэх нь тодорхойгүй бүтээлийн хувьд бол уг үгийг найруулга, зохиомжийн мадаг, зарим бүдэг дүр гэх мэтийн тухайд хэрэглэнэ. Хэрвээ тэр бүтээл аятайхан өнгөрвөл Вадимын дуу хоолой нийтийн магтаалтай ая хоршоод явчихна. Хэрвээ аль нэг бүтээл, түүний дотор түрүүн маш дээгүүр зиндаанд сайшаагдсан бүтээл ниргүүлэх юм бол Вадимыг нөгөө “болгоомж төрүүлж байна” хэмээх шидэт үг нь авардаг болой.

Дээрээс тогтоосон албан ёсны үзэл бодлыг, тэр нь нэгэнт хэлэгдсэн ч бай, эсвэл тиймэрхүү чигтэй ч бай, өөрийнхөө үгээр маш овжин томъёолдог нь Вадимын гол авьяас.

Иймэрхүү тохиолдолд цэг таслал ч алдахаас айж үг хэллэг нэг бүрчлэн давтдаг хоосон цээжлэгчид, мулгуу улиглагчдаас ялгаатай нь Вадим аль эрт бурхан болсон, тэр чанараараа аюул байхгүй зохиогчдын тансаг сайхан хэллэг, ишлэлийг бүр латинаар нь хүртэл иш татаж ашиглана. Чингэснээр өөрийн гэсэн байр суурьтай, хараат бус санаа бодолтой, төгс мэдлэгтэй мэт хүний хоосон дүр бүрдэнэ. Тэрээр засагт үнэнч, бас дэвшилттэй хэмээгдэх болжээ. Нэгдэхийнх нь төлөө утга зохиолын дарга нар, хоёрдахийнх нь төлөө утга зохиолын сэхээтнүүд түүнийг үнэлдэг юм байж.

Нэмэрт нь энгийн, ихэрхдэггүй, нийцтэй хүн. Ардчилсан хүн. Вадим энэ барилыг бүр сургуульд байхдаа, сэхээтэн гарлынхаа, бас хөрөнгөтний маягийн хүмүүжлийнхээ ч гэх үү,

илэрхий шинжүүдээс ангижрахыг хичээн тэр үеийн комсомолын гишүүд, 20-иод оны комсомолчдын ардчилсан төрхөнд зохицож явахдаа эзэмшсэн билээ.

Энэ ардчилсан зан, энэ ажилчны, энэ пролетарийн хээгүй арга барил нь одоо түүний амьтавин айдаг хэрнээ эн тэнцүүхэн мэт цэрвэхгүй харьцдаг хоосон цээжлэгчид, тотичлон улиглагчид, сохор дэлбэгчидтэй харилцахад нь яг хэрэг болдог аж. Нүүр нүүрээрээ уулзвал тэдний хий сүжирсэн маруухан өгүүллүүдийг магтан сайшаавч, олны индрээс хэзээ ч тийм юм ярихгүй. Улиглагчдыг индэр дээрээс бас хэзээ ч муу эс хэлнэ. Вадим ийнхүү оюун билигтний өндөр нэр хүндээ хадгалахын хамт дэлбэгчдийн итгэлийг бас эс алдана.

Тэрээр намд элсээгүй. мань хүн нам бус большевик, энэ бол хангалттай. Намын гишүүн большевикуудад тавих шаардлага шал өөр учраас эдүгээ нам бус большевикуудын ханш тэднийхээс хамаагүй өндөр байгаа.

Намын эгнээнд байх нь дээхэн үед л давуу талтай байж, одоо бол яг эсрэг. Намын баримт бичгийн шалгалт, цэвэрлэгээ энэ тэр гээд бүх юм алган дээр мэт. мань хүн намын гишүүн байсан бол дүү нь гадаадын хүнтэй суугаад гадагшаа явчихсаныг намын байгууллагадаа мэдэгдэх үүрэгтэй. Биш учраас энэ тухай хэнд ч илтгэж байх албагүй. Харин биеийн байцаалт дээр бол бичих үүрэгтэй, гэтэл аливаа биеийн байцаалт аль хэдийн бөглөгдчихсөн шүү дээ.

Нам бус учраас түүний байдал илүү чөлөөтэй.

Вадим улиглагч тотинуудтай нөхөрсгөөр ярилцахдаа хориотой бүс рүү орохгүй, цаадуул нь алдаа болгоныг отохоос гадна өөрснөө зуугаас, их сайндаа л зуун тавиас хэтрэхгүй үгийн сантай болохоор хүний үгийг тэр болгон ойлгохгүйг ч хэлэх үү.

Тэд өөрснийхөн дотроо бол өөр хэрэг, ямар ч ёгтлолыг бүгд ойлгоно, дор бүрдээ бусадтайгаа адилхан увайгүй амьтан, амьдрах нөхцөл, сэтгэлгээний арга энэ тэрийг байгаагаар нь хүлээн авч, яаж бичих шаардлагатай байна, түүнийг бичиж, яаж ярих шаардлагатай байна тэгж ярьцгаана. Хоорондоо ярилцахдаа ч дээрээс тогтоосон жаягаар ярьж, бахархах ёстой гэж дээрээс үзсэн юмаар бахархаж, муулах ёстой гэж дээрээс үзсэн юмыг муулна. Хөөрөхгүй бахархаж, бухимдахгүй муулна.

Яая гэхэв? Бялуунаас хувь зүгээр өгөхгүй, хөлс гаргаж байж авах хэрэгтэй.

Вадим яваандаа Викагийн тухайд ч тайвширчээ. Дүү нь яваад хагас жил болж байхад түүнээс хэн ч, юу ч асууж шалгаасангүй. Москвагийн мухлагуудад Парисын сонин борлуулдаггүй болохоор дүүгийнх нь нөхөр гүтгэлгийн дасгал хийж байгаа эсэхийг Вадим мэдэхгүй.

Вика гэртээ захиа бичиж болохгүйг эрхбиш ойлгоно. Өнгөрсөн хугацаанд Москвагийн шуудангийн тэмдэгтэй хоёр захиа ирсэн, бие хүнээр Москвад ирүүлсэн хэрэг. Амар мэндээ мэдүүлэх төдий маш товчхон захиа. Нелли Владимирова гэгчээр дамжуулж хариу өгөхийг хүсч түүний утсыг мэдээлжээ.

Вадим хариу захиа бичихийг эцэгтээ тас хоригложээ.

- Нелли Владимирова гэж хэн юм бэ? хэмээн Тэрээр асууна. -Бичсэн захиаг эхлээд Лубянкад аваачиж үзүүлэхгүй гэх баталгаа хаана байна? Энэ бол хилийн чанадтай хэлхээ холбоотой байна гэсэн үг, энэ яаж төгсөж мэдэхийг чи үнэхээр ойлгохгүй байна уу? Хилийн чанадтай захидлаар харилцдаг хүнийг надад хэлээд аль. Хилийн чанадад хамаатан садан нь байдаг хүмүүс түүнийгээ нууж байна, бид тэгэхэд зарлаад байх уу?

-Үгүй ээ, Вадим минь, би төрсөн охинтойгоо харилцаж болохгүй гэж үү дээ? хэмээн өвгөн гайхшран бугтнана.

-Болохгүй. Вика хүртэл үүнийг ойлгоод бидний хаягаар бичихгүй хүнээр дамжуулж байна, энэ аюултай, уршигтай гэдгийг мэдэж байгаа хэрэг.

-Гэхдээ л, Вадим минь!

-Аав аа, юмыг сийрэгхэн харж бай. Охин чинь биднийг хаясан, үүрд хаясан. Францаас наашаа буцаж ирдэггүй юм, яваад өгсөн хүмүүсийг бид ч эргүүлж авдаггүй юм. Тэр тэндхийн амьдралд шунасан, түүний явснаас болж энд манай амьдрал ямар болохыг бодоогүй, үнэндээ бол бодохыг ч хүсээгүй! Чи одоо биеийнхээ байцаалд “Охин гадаадад явсан, Францад суудаг” гэж бичих ёстой. Гэтэл би үзэл суртлын талбарт ажилтай, тэнд хилийн чанад руу одогсодын хамаатан хэрэггүй, тэнд тийм хүмүүст итгэдэггүй юм. Чи намайг зөвхөн өөрийгөө, зөвхөн өөрийнхөө дэвшихийг бодсон хар амиа хичээгч гэж үзэж байгааг би ойлголгүй яахав. Тийм биш шүү! Би юуны өмнө энэ асуудлын ёс зүй, ёс суртахууны талыг нь сонирхож байгаа юм. Тэр биднийг тоохгүй байхад бид яахаараа түүнийг тоох ёстой билээ? Тэр эндээс явснаараа л биднийг цохилтын бай болгосон, ингэсэн хүний өмнө нахилзаж байх ямар алба байна? түүнд ямар ч эрсдэл байхгүй, бид бүх юмаараа дэнчин тавьж байна. Тэр биднийг таягдан хаясан, түүний захиа бол ёс төдийхөн зүйл, төрөл төрөгсдийн сэтгэл гэгчийгээ л тайтгаруулж байгаа хэрэг... Тэгэлгүй яахав, аав минь, ах минь... Э-эх, мон пер, мон фрер. Францчууд тэгж уулгалах их дуртай... Энэ бол бааш... Аав минь, ийм л шүү дээ, би саяныхаа хэлснийг хатуу баримтлана.

-За, тэгвэл яахав, Вадим, чиний хэлж байгаагаар л болцгооё гэж Андрей Андреевич толгой дохив.

Тэгэвч профессор Марасевич Нелли Владимировад утасдаж, жижигхэн захиа аваачиж өгчээ: Вадим тэр хоёр сайн байгаа, бүх юм ёсоороо байна, Викагийн бүх юм сайн сайхан байгаад баяртай байна...

Өвгөн Неллид,

-Танаас ганцхан юм хүсье. Намайг захиа явуулсан гэж манай хүүд битгий хэлээрэй. Тэр дүүтэйгээ ойлголцохгүй байгаа юм хэмээжээ.

-Би танай хүүг танихгүй.

-Гэхдээ тааралдахыг, танилцахыг хэн байг гэхэв, тийм учраас битгий л хэлж үзээрэй.

-Үзье ээ гэж Нелли хайхрамжгүй өчив.

Профессор Марасевич охин нь захиа авснаа нотлоно гэдгийг тооцсонгүй. “Аав аа, чиний бяцхан мэдээг авлаа...” Тэр хариу нь Вадимд өртчихжээ.

-Энэ юу гээч вэ, надад тайлбарлаж өгч болох уу?

Эцэг нь дуугарч цөхөн, тэр хүүхэнд утасдаж мэнд уламжлахыг л гуйсан юм, ийм яльгүй юмыг асуудал болгохын хэрэг байх уу, Вадим энд огт холбогдолгүй, хөгшин хүний толгойд юу эс орохов гэхчилэн амандаа бувтнажээ.

-Чи яахаа өөрөө мэд. Гэхдээ цаашид ч захидлаар харилцах бодолтой байгаа бол чи бид хоёр салах ёстой болно гэж Вадим хүйтэн царайлав.

Профессор ойлгосонгүй.

-Тэр чинь яана гэсэн үг вэ?

-Яах юу байхав. Энэ байраа салгаж солино. Би тусдаа амьдрана.

Өвгөн тархиар нь татаад авсан мэт болчихов. Тэрээр Москва даяар мэдэх энэ байрнаас гадуур өөрийгөө төсөөлөх ч үгүй билээ. Одоо Викагаас хойш хүний хөл татарч, өөр айл болсон нь мэдээж. Сумбатов-Юшин нас барсан, Анатолий Васильевич Луначарский нас барсан, Екатерина Васильевна Гельцер өтлөсөн, Качалов, Игумнов энэ тэр ч өтлөсөн, гэхдээ утасдацгаана, өчигдөр, жишээ нь, Мейерхольд утасдсан, шинэ жил, төрсөн өдөр энэ Тэрээр баяр хүргэнэ, ирцгээнэ, зөвлөлгөө авна. Вадим нэг их хайхрахаа больсон учир театрын залуучууд үзэгдэх нь цөөрсөн, хуучин Андрей Андреевич ч тэднээс залхдаг байсан юм. Хилийн чанадаас зочид ирэх нь ховордсон; профессор шинэ хүнтэй танилцахгүй байгаа ч хуучин андууд нь Москвад ирэхээрээ заавал чимээ өгч тэднийд ирцгээнэ. Ингэхээр өөр байр гэдэг асуудал өвгөний толгойд яаж багтах вэ, авгайгүй, охингүй, ганц бие хүн, одоо хүүгээсээ салах нь. Вадимын хэлснийг тэгж ойлгох ёстой биз.

-Чи их хатуурхаж байна гэж Андрей Андреевич харамсан бувтнав.

-Намайг юу гэж бодно дураараа бол. Харин би чамд, миний хэр зэрэг зөв байсныг биеэрээ амсахаас бурхан хэлтрүүлэх болтугай л гэж хэлье. Чи хуучин маягийн ойлголттой юм, энэ бол сайн хэрэг, гэхдээ цаг үедээ таарахгүй байна, ойлгож байна уу,

таарахгүй байна. Үүнийг бодоорой.

Хүүгийнхээ далайлганаас айж мэгдсэн өвгөн,

-За яахав, Викториад би захиа бичихээ больё хэмээн үгэнд нь оров.

Үүгээр яриа дуусч, өрөө өрөө рүүгээ орцгоожээ.

Гэтэл өглөөгүүр утас дуугарч Вадим сэрэв... Чөтгөр авмар! Ийм эрт хэн ч утасддаггүй билээ.

Утсаа авгал үл таних эрэгтэй хүний албархуу дуу сонсдов.

-Вадим Андреевич Марасевич үү? Тантай Дотоод Явдлын Ардын Комиссариатаас ярьж байна. Өнөөдөр 12 цагт та Кузнецкий мост, 24, пропускийн товчоо гэсэн хаягаар нөхөр Альтман дээр очих хэрэгтэй. Ойлгов уу?

-За, би ойлголоо хэмээн Вадим хоолой нь тэр даруй сөөнгөтөн хариулав.

-Паспортаа авч очно шүү. Ойлгов уу?

-Ойлголгүй яахав.

Утас тасран гонгинож, Вадим ч харилцуураа тавилаа.

За тэгнэ ээ тэр! Эрт орой хэзээ боловч ингэж төгсөнө гэдгийг Тэрээр мэдэж байсан. Новш! Янхан! Завхай эм! Хэзээний завхай эм. Энд завхайрч байсан юм чинь Парист ч бас тэгнэ дээ.

Ээ, чөтгөр! Өнөөдөр завгүй гэж хэлэх минь яалаа. Хурал зөвлөл-гөөнтэй, өнөөдөр чадахгүй гэж... Бас яагаад утсаар дуудаж байна? Хэрэв ямар нэгэн буруутай юм бол албан ёсоор зарлан дуудах явуулна биз. Нэг муу бандь байгаа биз! Зохиолчдын эвлэлийн гишүүн, тэгж яривал улсдаа адагт нь орохгүй шүүмжлэгч. Т э н д түүнийг мэдэхгүй байх ёсгүй, өгүүлэл энэ тэрийг нь уншаа л даа, түүнтэй ярилцах гэж байгаа юм бол уншсан байх албатай.

Үгүй, ингэхэд, чухамхүү тэр учраас зарлан дуудах явуулаагүй байх. Викатай захидлаар харилцсанаас болж түүнд ч, эцэгт нь ч сүүдэр тусч байна, тийм учраас бичилцэх хэрэггүй гэж урьдчилан сануулах гэж байх нь. Сайн санасандаа л утсаар дуудсан хэрэг. Тэр хүний шижээргүй дуу бол яахав зүгээр л нэг гүйцэтгэгч утасдаа шүү дээ.

Ер нь ч түүнийг юугаар буруутгах вэ дээ? Дүүтэйгээ аль хэзээ, бүр Парис руу явахаас нь өмнө муудалцаж харилцаагүй болсон. Тэрээр комсомолын гишүүн явсан хүн, дүү нь бол рестораны эрвээхэй. Тэрэндээ хүрвэл тэр хоёр сүүлийн гурван жил хоорондоо дуугараагүй. Тэгвэл эцэг? Зөнөсөн өвгөнийг яах вэ дээ, гэр бүлийн заншил, төрсөн охин энэ тэр гээд байх юм чинь.

Ээ, бурхан минь... Тэндээс гэнэтхэн гаргахгүй бол яана?! Тэр ч үгүй юм аа, баривчлахад чинь зөвшөөрөл байх ёстой. Тэглээ ч гэсэн энэ байгууллага тун зэвүүн санагдана. Багадаа бэмбэгнэж өссөн айдас, комсомолд элссэнээр арилах шиг болсон нөгөө айдас нь түүнийг дахиад эзэмдээд ирлээ. Өнөөгийнх нь байр суурь хичнээн тогтвортой юм шиг байлаа даа. Хамгийн тууштай шүүмжлэгчийн нэг. Чухамдаа Ермилов мэтийн эвэр духтнуудын гарын “сэхээтэн бороохой” болсон юм чинь эх орондоо хэрэгтэй хүн! Юунаас ч айх ёсгүй. Үнэхээр, чухам түүн шиг хүмүүс л улсад хэрэгтэй, тэр дуудаад байгаа газар нь үүнийг ойлгож байх ёстой.

Тэрээр толины өмнө зангиагаа зангидав. Чөтгөр чамайг! Гар нь чичирч байна. Зангианы нэг үзүүр гогцоондоо орж өгдөггүй. Арван хоёр цаг дөхөж буйг ч хэлэх үү.

Эцэг яаж тийм тэнэг юм хийж зүрхлэв ээ, хахь хамаагүй Нелли Владимировад утасдсан байгаа юм, тэр нь “алтан хошуу” өргөгч юмсан уу, уул нь эцэгтээ урьдаас сануулсан, эцэг хэдийгээр зиндаа дээгүүр яваа ч юм болгоноос айдаг хэвээрээ шүү дээ. Түүгээр эмчлүүлдэг өндөр албаныхныг шоронд хийж байна, цөлж байна, тэгээд түүний мэргэжил нэгтнүүд, нөгөө мундаг алдартан, профессорууд чинь айдаст автан чичирцгээж байна. Тэгвэл Вадимын өөрийнх нь мэргэшил нэгтнүүд? Оюун бодлыг эзэрхэгчдийн дүр эсгээд байгаа хэрнээ л бас айдаст автан чичирцгээж байгаа. Сүүдрээсээ хүртэл айцгаана. Хэрвээ мань хүнд ямар нэг юм тохиолдвол цаадуул нь салхинд хийссэн мэт алга болчихно, нэг нь ч хань болохгүй, харин ч зэвүүцэж жигшицгээнэ. Бид яагаад “олж харсангүй вэ?” гэцгээнэ. Тэрээр цаадуулынхаа биеэ үгүйлэхгүй ихэмсэг инээмсэглэл, юу ч мэдэхгүй байж мэдэмхийрдэг занг сайн мэднэ.

Юрка Шароктай зөвлөдөг юм бил үү?

Тэр хоёр, үнэндээ, ойр найр уулзаагүй. Гэхдээ багын найзууд, бараг есөн жил нэг ширээний ард суусан найзууд. Бас хожим ч уулзалдаж байсан... Юра эднийд хичнээн ирсэн, Вадимын өөрийнх нь урилгаар театрт хичнээн орсон билээ дээ. Сургуулийн найзладаг бүлгээс мөн чанартаа тэр хоёр л үлдэж.

Юрка туслах ёстой. Тэдэндээ тайлбарлаж өгөг. Вадим Кремлийн эмнэлгийн зөвлөх, нэрт профессор Марасевичийн хүү төдийгүй, өөрөө нэртэй шүүмжлэгч гэдгийг тэр Альтман гэгч гадарлаа ч үгүй байж мэднэ.

түүнээс гадна, гол нь Вадим Зөвлөлт засгийн байр суурин дээр бат зогсож байгаа гэдгийг Юрка нотлоно.

Нээрэн, Юра руу утасдаж зөвлөх хэрэгтэй, гэхдээ санаа зовж буйгаа харуулахгүй, нэр нүүрээ хадгалан, зүгээр санаандгүй мэт ярьж үзье.

Өө тийм, Юрад ч бас санаа зовох үндэс бий. Вика тэр хоёрын хооронд нэг юм болсон, тэр бол гарцаагүй. Нэг удаа гэртээ ирээд Викагийн өрөөгөөр ортол Юра тэнд сууж байсан, тэгээд л тэр хоёрын царайгаар Вадим бүгдийг ойлгосон билээ. түүнээс өмнө Нинагийн шинэ жил тэмдэглэхэд тэр хоёр нэг буланд шахалдаад зүгээргүй байсан. Нина бүр шуугиан дэгдээсэн шүү дээ. Харин Юрка ДЯАК-д ажиллах болсноос хойш тэднийхээр үзэгдэхээ больсон, гэхдээ тэр хоёр гадуур уулздаг ч байсан юмсан уу, хэн тэднийг мэдэхэв. Вика хормойн донтой, Юра ч хүүхэмсэг. Товчдоо, Юра түүнд туслах ёстой, туслахгүй байх ёсгүй.

Юрагийн дугаарыг залгатал бөглүү барлаг дуу гарсан нь түүний оёдолчин эцгийнх байж. мань хүн мөн заяагүй шүү, өвгөний хос нэрийг ч мэддэггүй.

-Эзгүй байна, хэзээ ирэхийг мэдэхгүй гэж сайхь бөглүү хүнийрхүү дуу өчлөө.

Тэгээд утсаа тавьчихав.

За-ааг... Юрагийн ажлын утсыг мань хүн мэдэхгүй. Ер нь ч тиймэрхүү юмыг утсаар ярих биш. Яадаг хэрэг вэ?

Тэр Альтман гэгч ямар хүн юм бол? Залуу юу, хөгшин үү? Сэхээтэн үү, барлаг уу? Ер нь бол Альтман гэж сэхээтний л овог доо.

Натан Альтман гэж Владимир Ильич Лениний цуврал таталбар зураг, өөрөөс нь харж бүтээсэн баримал хөрөг энэ Тэрээрээ нэрд гарсан зураач бий. Уран зураач, жүжгийн тайз чимэглэл ч хийнэ. Бүтээл нь хийсвэрлэл, бүдүүвчлэлийн мэдэгдэхүйц хольцтой. Вадим тэр тухай бичиж байсан.

Өөр нэг Альтман нь Иоган, утга зохиол судлагч, театрын шүүмжлэгч, намын ахмад гишүүн, одоо “Советское искусство” сонины редактор.

Ингээд бодоход одооны энэ Альтман ч сэхээтэн байж магадгүй.

Сэхээтэн л байвал сайн сан, хэл амаа олоход эрхбиш амар. Барлаг бол? Савхин гуталтай, мохоор татаж, пролетарийн дүр эсгэн зориуд тамхиа ханхлуулаад, мундаг амьтан өрөөндөө сууж байгаа даа.

Вадим сүүлийн хэдэн жилд барлагуудтай өөрсдөд нь дүйлгэн харилцаж сурсан, тэднээс айхаа аль хэдийн больсон гэлтэй. Үгүй юм аа! Хөгшин Шарокийн дууг сонсоод бүр балмагдчихсан, тэгэхээр тэднээс айдаг, чичирдэг нь хэвээр байх нь.

Ингэж бодохоос Лубянкад өөрийг нь хүлээгээд сууж буй тэр үл мэдэх, нууцлаг, хүчирхэг барлагаас Вадим улам бэмбэн бантжээ.

Тэр хүчирхэг барлаг нь цэргийн хувцастай, унжуу хамартай, гунигт харцтай, бөгтөр шар еврей байв.

Вадим түүнийг үзээд сэтгэл онгойх мэт санаа алджээ. Овог нэгтэй алдартнуудынхаа тухай энэ хатингар шар толгойт лав сонсоогүй, боловсрол нь зургаа-наймдугаар ангийн хавьд болов уу, гэхдээ барлагтай төсгүй аж. Хацар нь ёнхойж, мөр нь хавчийгаад... Багадаа хийл хөрөөдөж байсан байж ч магадгүй, ямар ч атугай хоёр хуруугаараа нусаа нийхгүй, нусны алчуур хэрэглэж харагдана. Байцаагдагчийг арай гарыг нь мушгиад байдаггүй болов уу гэж бодохоор.

-Та суу!

Вадим суулаа. Альтман ширээнээсээ маягт гаргаж өмнөө тавиад үзгээ бэхэнд дүрэв.

-Овог, нэр? Төрсөн он, газар? Ажил, албан тушаал?

Байцаалт уу? Юуны учир, яагаад? Нэмэрт нь Альтманы нэгэн хэмийн дуу эгдүү хүргэнэ.

Сүүлчийнх нь асуултад Вадим ингэж хариулав:

-ЗСБНХУ-ын Зохиолчдын эвлэлийн гишүүн. Би юуг... мэдмээр байна.

-Мэдэх болно гэж Альтман үгийг нь тасдав. -Албан тушаал?

-Зохиолчдын эвлэлд албан тушаал гэж байхгүй.

Альтман түүнийг гайхан харав.

-Та тэнд юу хийдэг юм бэ?

-Би шүүмжлэгч, утга зохиол, театрын шүүмжлэгч.

Альтман түүнийг дахиад ширтэв.

-Өгүүлэл бичиж, түүндээ шагнал авдаг юм гэж Вадим тодруулав.

Альтман хэсэг бодлогошрон харлаа. Тэгснээ “шүүмжлэгч” гэж бичив.

Вадим энэ бяцхан амжилтад сэргэж,

-Шагналын хэмжээ, мэдээж, шалихгүй л дээ, энэ чанараараа бол шүүмжлэгчийн хөдөлмөр буян багатай, унацгүй ажил. Гэхдээ болж л байна... Би эцэгтэйгээ хоюулаа байдаг, миний эцэг-профессор Марасевич... гэж нэмж өгүүлснээ, ийм мундаг нэрийг сонсоод Альтман яах бол хэмээн чимээгүй болзносон боловч түүний царай хүний урманд өчүүхэн төдий ч хувьсхийсэнгүйд Вадим, -Нэг эмнэлгийн удирдагч, Кремлийн эмнэлгийн зөвлөх гэж гүйцээв.

Альтманы уйтгарт царайд дахиад юу ч мэдэгдсэнгүй. Тэрээр хуудсаа эргүүлж, нугалааг нь хумсаараа шилэмдэж засав.

Зөвхөн шугамтай цэвэрхэн цаасаа ширтэх зуур,

-Та хэнтэй эсэргүү юм ярьж байсан бэ? гэж царай шигээ уйтгартай, нэгэн хэмийн дуугаар асуув.

Вадим ингэнэ чинээ даанч санасангүй. Викагийн тухай ярина гэж бодоод, тэр тухай бэлтгэж, өөрийнх нь дүгнэснээр бол, учир авцаа сайтай, үнэмшилтэй хариутай ирсэн билээ. Гэтэл “Та хэнтэй эсэргүү юм ярьж байсан бэ?!” хэнтэй ч эсэргүү юм яриагүй, ярьсан байх ч учиргүй, Тэрээр зөвлөлтийн хүн, зөвлөлтийн шударга хүн. Ийм асуулт бол урхи. Ямар хэргээр дуудсанаа хэлэг, хариулахад бэлэн байгаа ч ямар учиртай, юу болоод байгааг эхлээд мэдэх ёстой. Гэтэл ингээд зөрөөд эхлэвэл энэ мулгуугийн гэдэнг хөдөлгөчихнө, энэ бол энүүхэн төмөр тортой, тэг дунд нь хүртэл будсан цонхтой нүцгэн дөрвөн ханан дотроо ганцаар эрхт эзэн.

-Би таны асуултыг сайн ойлгосонгүй, ямар яриаг та хэлж байна вэ? Би...

Альтман түүний үгийг таслав:

-Та миний асуултыг маш сайн ойлгож байгаа. Ямар танилыг чинь хэлж байгааг та маш сайн мэдэж байгаа. Шудрага, нууж хаахгүй ярихыг танд зөвлөе. Хаана байгаагаа битгий мартаарай.

-Би үнэндээ мэдэхгүй байна, би хэнтэй ч эсэргүү юм ярьсан байх учиргүй. Нэг л эндүүрэл болж дээ гэж Вадим гүвтнэв.

Альтман байцаалтынхаа хуудас руу харав.

-Та Зохиолчдын эвлэлийн гишүүн, тийм үү? Таны эргэн тойронд зохиолчид байдаг уу? Таныхаар бол тэдний хэн нь ч эсэргүү юм ярьдаггүй болж байна уу? Тэрээр нэгэн хэмийн дуугаар Вадимаас асуух биш түүнд сургаал номлох мэт дараалсан асуулт урсгав. -Та үүнийг надад үнэмшүүлэх гээ юү? Бүх зохиолчид Зөвлөлт засагт туйлын үнэнч гэж надад нотлох гэж байна уу? Та үүнийг нотлох гээд байна уу? Та бүх зохиолчид, бүх сэхээтний өмнөөс хариуцлагыг өөртөө авч байна уу? Та өөртөө дэндүү их хариуцлага авч байгаа юм биш биз?

Вадим дуугарсангүй.

-За яахав? Жимийлцэж тоглох хэрэг үү, а-аан? гэж Альтман давтан асуув.

Вадим түхгэр мөрөө хавчив.

-Надтай эсэргүү юм ярьсан хүн даан ч байхгүй.

-Бидэнд туслахыг хүсэхгүй л байна даа гэж Альтман битүү заналхийлэв.

-Яагаад хүсэхгүй байна гэж, ДЯАКГ-ын байгууллагад туслах чинь хүн болгоны үүрэг гэж Вадим зөрөв. -Харин ямарваа нэг яриа байгаагүй. Би өөрөө зохиолтой нь биш.

Энэ өрөө, энэ нэгэн хэмийн дуутай, автомат гэлтэй Альтман, эндхийн бүхий л байдал Вадимд айдас төрүүлж байгаа ч Тэрээр дотуураа яльгүй уужрав. мань хүний хөндүүр газар бол Вика, гэтэл түүний талаар ямар ч асуулт алга. Эсэргүү ярианы хувьд бол ямар нэг алдаа, эндүүрэл л гарч дээ.

Альтман дуугүй сууна. Харцанд нь санаа ч алга, сэрэл ч алга. Тэгснээ хуудсаа буцаан эргүүлж Вадимын овог нэрийг харав.

-Вадим Андреевич!

Энэ бол доромжилсонтой адил. Альтман түүний хослоо нэрийг нь ч санахгүй буйгаа нуухгүй байна. Тогтоох гэж оролдсонгүй, ямар ч хэрэггүй зүйл байх нь.

-Вадим Андреевич!

Тэрээр анх удаагаа Вадимын нүд рүү эгцлэн харлаа. Алуурчийн энэ цэвдэг сүүмгэр харцанд ямар их хорсол хураа вэ. Вадимын нуруу руу хүйтэн оргиод явчихлаа.

-Харин би...

-Юуны чинь “би”, “би”, -Альтманы бөглүү дуу үзэн ядсан чарлаан болон дэлбэрэхэд бэлэн гэлтэй. -Би танд дахин хэлье: Та хаа байгаагаа мартаад байна. Манийг гэгээрүүлж өгөөч гэж

бид таныг дуудсан юм биш, та үүнийг ойлгож байна уу, үгүй юү?

-Тэгэлгүй яахав, мэдээж гэж Вадим зулгуйдан өчив.

Альтман чимээгүй байзнаснаа нөгөө бөглүү дуугаараа,

-Гадаадын харъяат ямар хүмүүстэй та уулздаг вэ? гэж асуулаа.

Тэгнээ тэр! Вика дээр буух нь. Яг даа!

Вадим ойлгож ядсан царай гаргаж,

-Би хувьдаа гадаадын ямар ч хүнтэй уулздаггүй гэв.

Альтман дахиад нүд рүү нь эгцлэн харахад, тэрхүү алуурчийн сүүмгэр харцнаас Вадимын хамаг бие нь дахин хүйтэн оргиод явчихав.

-Та ер нь насандаа нэг ч гадаадын хүн үзээгүй юм биш биз дээ?

-Яагаад тэр билээ? Үзэлгүй яахав.

-Хаана?

-Гадаадынхан манай эцгийнхээр бишгүй орж гарна л даа. Миний эцэг-анагаахын профессор, дэлхийд нэртэй томоохон мэргэжилтэн... Тийм учраас, түүн дээр гадаадын эрдэмтэд, мэдээж, ирнэ, гэхдээ энэ бүхэн удирдах байгууллагын зөвшөөрлөөр албан ёсоор хийгдэнэ... Би тэднийг тун бага мэднэ, би анагаахын хүн биш, тэдний ярианд ерөөсөө оролцдоггүй, харин тэдний яриан дээр албаны хүмүүс байнга байлцдаг байсан... Гэхдээ би зарим нэг нэрийг санаж байна. Хэдэн жилийн өмнө Берлиний их сургуулийн профессор Крамер аав дээр ирсэн, өөр бас нэг профессор, Россо-лини гэдэг шиг санагдана. Колумбын их сургуулийн профессор, овгийг нь санахгүй байна, түүнийг Сэм Вениаминович гэгцгээж байсан.

Альтман цаасан дээр нэг юм тэмдэглэж авав. Энэ профессоруудын нэрийг бичиж авлаа гэж үү? Хачин юм! Тэдний тухай сониноос уншсан ч болно. Вадим тэднийд гадаадынхантай ирж байсан профессор Игумнов, Анатолий Васильевич Луначарский хоёрын нэрийг дурсав. Польшийн нэг профессорыг нэрлэжээ. Тэр хүн Владимир Ильич Лениний найз, журмын нөхөр, намын нэртэй ажилтан Глинскийтэй цуг ирж байсан юм. Өөр ч бас хэдэн хүнийг нэрлэлээ.

Тэгээд чимээгүй болов.

Альтман ч нэг хэсэг чимээгүй байснаа,

-За тэгээд тэр гадаадынхантай юун тухай ярьж байв даа? гэж асуулаа.

-Би хувьдаа юуны ч тухай яриагүй. Тэд бол аавын танилууд.

-Та тэдэнтэй цуг хооллох уу?

-Заримдаа.

-Тэгээд?

-Би ойлгохгүй байна...

-Тэгээд? гэж би асууж байна. Ширээний ард юу хийж байв?

Ярьж байсан уу?

-Үгүй, надад тэдэнтэй ярих юм байгаагүй, тэд нар шинжлэх ухааны хүмүүс.

-Өө, ярьдаггүй байх нь. Зөвхөн ууж, идээд л. Чихээ яах вэ? Хөвөнгөөр бөглөчих үү? Үгүй юу? Тэгвэл ууж, идэж, тэдний яриаг сонсож байж. Тэд нар юун тухай ярихав дээ?

-Янз бүрийн сэдвээр, гол нь анагаах ухаанаар.

-Хөгжмийн удирдаачтай бас анагаах ухаанаар уу?

Энд Вадим өөрийнх нь бодлоор бол маш оновчтой хариу олж, өөрөө ч түүндээ сэргэсхийгээд ирэв:

-Тийм, бас анагаах ухаанаар. Тэр өөрийнхөө өвчний талаар манай аавтай зөвлөдөг юм.

Альтман цаасаа авч, Вадимын дурдсан нэрсийг өргөлтийг нь буруу зөрүү дуудан байж уншив.

-Ингээд гүйцээ юү?

түүний нэгэн хэмийн дуунаас “ингээд гүйцээгүй” гэсэн итгэл тов тод мэдэгдэв.

-Гүйцэх шиг л боллоо.

-Бод доо.

Дахиад л түүний дуунаас, Вадимаар ганцхан нэр хэлүүлэх гэж дуудсан, чухамхүү тэр нэрээ л хэлэхийг хүлээж байгаа аяс тодхон мэдэгдэв.

Вадимд бүх юм тодорхой болов: Мөрдөн байцаагч Шарлийг л хэлж байна, Викагийн нөхөр шүү юмыг, тэр муу гүнтнийг хэлж байна, ёстой чөтгөр алгадмар! Тэр Вика дээр ирдэг байсан, гэхдээ Вадим түүнийг бараг хараагүй, анх удаа танилцуулахад нь хайнга мэндлээд, оройн хоол ч цуг идэлгүй, яаралтай хуралтай гээд яваад өгсөн, тийм болохоор Вика Шарлийгаа өөрийнх нь зөвшөөрөлгүй төдийгүй өөрийнх нь оролцоогүйгээр гэртээ о р у у л с а н. Одоо хамаг хэргийн учир Шарль болох нь, гагцхүү Шарль. Тэгэхээр түүнийг нэрлэх хэрэгтэй, албадлагаар биш, өөрөө сандралгүй тайван нэрлэх хэрэгтэй.

-За бас, миний дүүгийн нөхөр бий, тэднийх Парист суудаг юм... Гэхдээ би тэдэнтэй ямар ч харилцаа байхгүй гэж Вадим хэлэв.

-Ингээд гүйцээ юү?

-Тийм, санаанд орох юм гүйцлээ.

Альтман маягтаа ойртуулж, Вадимын нэрлэсэн хүмүүсийн нэр овгоор дүүргэсэн цаасаа харж байгаад бичээчийн жигдхэн бичлэгээр бичиж гарлаа.

Вадим түүний хэрхэн бичиж буйг ажиглав. хэн ч зогсоож чадахгүй зугуухан, тайван ажил. Энэ ажлын цаанаа л нэг зайлбаргүй байдал нь аймшигтай санагдаж, Вадим дотроо сүрдэн бэмбэгнэв.

Альтман бичиж дуусаад түүн рүү тэмдэглэлээ сарвайв.

-Уншаад гарын үсгээ зураарай.

Тэгээд нөгөө л үзэн ядсан харцаараа түүнийг ширтэв. Вадимыг дүүжилсэн нь дээр үү, толгойг нь тасдсан нь дээр үү гэдгийг шийдэж байгаа мэт. Вадим энэ харцнаас эмээхдээ жихүүцэн биеэ хурааж, тэрхүү тэмдэглэлийг уншихчаан болов.

Догол мөр энэ тэр байхгүй хоёр хуудас энэ тэмдэглэл “Та хаана, хэзээ, хэний дэргэд гадаадын харьяат ямар хүмүүстэй уулзаж байсан бэ?” гэдэг асуултын хариуг агуулжээ.

Вадимын дурдсан овог, нэрсийг зөв бичжээ. Орос, гадаад холилдсон маш олон нэр. Гадаад нэрс нь Арбатад, тэднийд ирсэн хүмүүсийнх, орос нь тэднийг дагуулж ирсэн оросуудынх, харин бичигдсэн зүйл нь тэднийд сав л хийвэл гадаадынхан ирээд байдаг, Вадим зөвхөн тэдэнтэй л ярилцаж байдаг юм шиг, утгагүй, үнэнд хавьтахгүй юм болжээ. Нэмэрт нь бүх юм Викагаас, түүний тийм тийм, тэгдэг тэгдэг, франц хүнтэй сууснаас нь эхлэж бичсэн учир чухамхүү үүнээс үүдэн гадаадынхан тэднийд очдог юм шиг болчихжээ.

Гэхдээ өнгөнөөсөө бол бүх юм Вадимын мэдүүлэгтэй тохирч буй тул өөчлөх юм алга, ер нь ч өөчилж зөрнө гэхээс аймшигтай. Энэ алуурчийн сүүмгэр харц, нэгэн хэмийн нугаслах мэт дуу, гэнэ гэнэ үзэн ядсан цочир уур түүнийг дарамталж гүйцлээ. Бушуухан салах минь. Вадим тэмдэглэлийн хоёр хуудсан дээр гарын үсгээ зурлаа.

Альтман тэмдэглэлээ авч хавтсанд хийв.

-Ийшээ дуудагдсан, ямар мэдүүлэг өгсөн тухай хэн ч мэдэх ёсгүй. Ойлгомжтой юу?

-Тэгэлгүй яахав гэж Вадим бачимдан хариулав. Тэрээр эндээс л бушуухан явж байвал юуг ч зөвшөөрөхөд бэлэн байжээ.

-Та хэнд ч, юу ч ярих ёсгүй. Эс тэгвэл танд их тусгүй юм болно.

-Өө, хаанаас даа!

-Албан ёсоор урьдчилан сануулсан гэж мэдээрэй.

-Ойлгомжтой.

Альтман толгойгоо өргөж, дахиад хорсолтой сүүмийн харлаа.

-Нөгөө эсэргүү ярианы чинь тухайд бид эргэж ярилцана. Тодорхой ярилцамз. Би танд утасдана.

Варя, мэдээж, Вика руу утасдсангүй. Бас Вика ч түүн рүү ярьсангүй. Бурханы аврал! Тэр нэгэн амьдралаас үүрд хагацах нь энэ.

Тэрээр Левочка, Рина хоёртой зөвхөн ажил дээрээ л тааралдана. Левочка нэг удаа ам нээж үзсэн, тэгэхэд нь мань хүн тас ширэвсэн, тэгэхгүй бол болохгүй, сайн мэдэж аваг. Левочка сайн ойлгосон байх, түүнээс хойш дахиж ам нээгээгүй, Рина бол бүр таг, тэр дэнгийн эрвээхэйд яасан ч ялгаагүй л дээ.

Игорь Владимирович хуучин янзаар анхаарал халамжтай түвшин харилцана. Гэхдээ Костя тэр хоёрыг салснаас хойш Игорь Владими-ровичид горьдлого төрөх болсон, түүнийгээ илт боловсон харьцаагаар далдалж явааг Варя мэдэрчээ. Үйлдвэрчний хурал, “Канатик”-ийн явдал энэ тэрээс хойш түүний тухай Варягийн үнэлгээ их буурсан. Хэдийгээр сайн дарга, маргаангүй авьяастай уран барилгач ч гэсэн бусдын адил туулай зүрхтэн.

Игорь Владимирович барилгын техникийн асуудал хэлэлцэх зөвлөлгөөнд төсөл, саналаа хэлэлцүүлэхээр явахдаа зөвхөн Варяг л дагуулж явна.

Варя ч тэгж явахдаа дуртай. Тийм зөвлөлгөөн аятайхан байдалд болно. Салбартаа хамгийн нэртэй, ухаантай, боловсон хүмүүс цугларна. Яваандаа өөрөө ч зочид буудлын барилгын нарийн төвөгтэй асуудлуудын учрыг олж, тэгснээрээ Игорь Владимировичийн өргөн мэдлэг, нарийн ухааныг үнэлж чадах болжээ. Тэрээр эдгээр гарамгай хүмүүсийн дундаас хүртэл товойн ялгарч байгаа нь Варяг зарим талаар түүнтэй эвлэрүүлж байгаа билээ.

Тэр бол бусдын адил айдаст махлуулж яваа хүн, уул нь баатар биш ч хүний шаар бас биш, журамтай шудрага чигээрээ байхыг чадах чинээгээрээ эрмэлзэнэ, ажил мэргэжилдээ дуртай, бүтээлч хүн, гэхдээ халирхай. Ийм бүтээлч, авьяаслаг хүмүүс халирхай байх нь элбэг бололтой. Сонин гүйлгээд харахад л илт. Алдартай зохиолчид, жүжигчид, зураачид гэм буруу нь нотлогдоогүй хүмүүсийг хөнөөх, устгах, буудан алах шаардлагын бичигт гарын үсгээ зураад байх юм. Зохиолчид, жүжигчид, зураачид үй олноороо тагнана, үй олноороо хорлон сүйтгэнэ гэдэгт үнэхээр итгэж байна гэж үү? Варя хүртэл итгэхгүй байгаа юм чинь тэд нар ч итгэхгүй байгаа, харин айцгаагаад байна.

Элдэв шаардлагын бичигт гарын үсэг зурдаггүй болохоор Игорь Владимировичийн нэрийг Варя, бурхан өршөөг, сониноос олж хараагүй, түүний үйлдвэрчний хурал дээр бас “Канатик”-т гаргасан арчаагүй царай тухайн үедээ зэвүүг нь хүргэсэн ч гэсэн бүхэлдээ бол шалихгүй зүйл.

Тэр хоёрын зам таарч, ажлын дараа Игорь Владимирович түүнийг хэд хэдэн удаа дөхүүлж өгчээ... Нэг удаа, яагаад ч юм, Герцений гудамжаар явж байгаад “Хүүхдийнхээ төлөө” гэдэг кино цуг үзжээ. Аятайхан кино байж.

Маргааш нь Улаан талбайгаар уруудан Москва гол руу очиж, эрэгний хашлага дээр суугаад, хажуугаар өнгөрөх хүмүүст элдэв хувь тавилан зохиож хөөрөлджээ.

Бас нэг удаа Арбатын талбай дээр метроны дэргэдээс Игорь Владимирович гурван сарнай авч өгөхөд Варя эвлүүлж барих гэж байгаад нэгийг нь унагаж, араас нь хоюулаа зэрэг тонгойн духаараа мөргөлдөж, бөөн инээд болжээ.

Ийм зугаалга эргүүлдэх янз руу шилжиж, аюултай болж эхлэв. Варягийн огт хүсэхгүй буй зүйл тэр. Тэгээд Зояг дагуулж явдаг болжээ. Тэр хоёр нэг байшингийнх юм чинь хүн гайхах юм алга. Игорь Владимирович дургүйцлээ илэрхийлээгүй, хуучин янзаар тоглоом, инээдэм болж байвч, урам хугарсан нь илт. Маргааш нь Зоя дахиад хамт байхыг үзмэгц,

-Воздвиженка хүртэл би та хоёртой зам нийлэх юм байна гэж өгүүлжээ.

Тэгээд гудамжны булан дээр очоод, баяртай хэмээн салж оджээ.

Дараа нь нэг удаа Варя Игорь Владимирович хоёр зэрэг гарч таарчээ. Зоя байсангүй. Варя,

-Игорь Владимирович, би яарч байна, трамвайгаар явна гэв.

-Би таныг трамвайд суулгаж өгье.

Тэрээр юм дуугаралгүй буудал хүргэж, мөн дуугүй зогсож байгаад трамвай ирэхэд,

-Тань руу утасдвал зөвшөөрөх үү? гэж гэнэтхэн асуув.

-Утасд л даа гэж Варя трамвайд суунгаа хариулав.

мань хүн утасдаагүй, харин сагс цэцэг хүргүүлжээ.

-Энэ юу вэ, бас нэг шүтэгч үү? гэж Нина асуулаа.

-Магадгүй.

Сайхан цэцэг, гэхдээ түүнд ийм юм хэрэггүй. Тэр Игорь Владимировичид сэтгэлгүй, хэзээ ч сэтгэлтэй болохгүй. түүнд сэтгэлтэй болно гэдэг бол түүний адил өнөөгийн бүх дэг журамтай эвлэрнэ гэсэн үг.

мань хүүхэн Сашаг хүлээж байгаа... Тэрээр Софья Александров-нагийн сүүлчийн захидал дээр “Эрхэм Саша минь, бид чамайг хүлээж байна” гэж нэмж бичжээ. Тэгснээ “Бид хүлээж байна” гэснийгээ дараад “Би хүлээж байна” гэж бичжээ.

Софья Александровна бичсэнийг нь харснаа инээмсэглэж,

-Варя, баярлалаа, Саша уншаад баярлана даа гэв.

Цэцгийг буцаах нь, мэдээж, мунхаг хэрэг. Москва дундуур ийм цэцэг тэврээд явж байлтай нь биш?.. Бас ажил дээрээ учраа ололцоно гэвэл бас л мулгуу явдал болно.

Варя Игорь Владимировичид захиа бичихээр шийджээ.

“хүндэт Игорь Владимирович! Тансаг гоё цэцгээр сайхан бэлэг барьсанд тань баярлалаа. Харин манай муу нийтийн байрныхан тэр сагснаас болж багагүй үймж, бас миний хуучин нөхөртэй холбон хэл амаа чамгүй билүүдлээ. Цаашид манай хөршүүдийн сэтгэлийг зовоохгүйн тулд, хэл амаа билүүдэх шалтаг өгөхгүйн тулд дахиж цэцэг илгээхгүй байхыг танаас хүсье. Ихэд хүндлэн ёслосон, Варя”.

Тэрээр маргааш нь Игорь Владимировичийн өрөөнд орж, ширээн дээр нь захидлаа тавиад,

-Уншаарай, харин битгий уурлаарай хэмээн инээмсэглэн гарчээ.

Хэсэг хугацааны дараа Игорь Владимирович тэдний өрөөгөөр орж, Варягийн зурвасыг уншсан, ойлгосныхоо тэмдэг болгож түүн рүү нэгэнтээ инээмсэглэжээ.

Варя өдөр, оройн цагаар зав муутай ч Софья Александровнаг эргэх, Михаил Юрьевичийнхээр шүргэх цаг яаж ийгээд гаргана. Уулзахыг хүсдэг хүн нь ердөө л тэр хоёр.

Софья Александровнагийн зүрх муу. Хэдийгээр өөрөө ийм тийм гэхгүй ч, сандлаасаа зовж босч байгаа, амьсгаа нь багтраад байгаа, үрэл хүртээд байгааг нь Варя анзааралгүй яахав.

-Софья Александровна, танд яаж туслах вэ?

-Зүгээр, ингээд гайгүй болно, Сашаг эргэж иртэл дөнгөөд тэснэ гэж Софья Александровна бэлэн хариулна.

-Боль доо, Софья Александровна, наад бодлоо толгойноосоо авч хая гэж Варя дүрэмдэнэ. - Таны шаналж байгааг хараад байх арга алга. Одоо болоо. Эмнэлэгт үзүүлэхээр бэлтгэж бай, би цуг явна.

-Чи ажилтай, сургуультай хүн, яаж зав байхав. Эмч дээр орох гэж өдөржингөө оочерлож хүлээх болдог юм.

-Зүгээр, би амралтаасаа хоёр өдөр урьдчилаад авчихна.

Варя маргааш орой нь хүрээд ирэв.

-Софья Александровна, маргааш явна шүү, би ажлынхантайгаа тохирчихсон.

Софья Александровна түргэн явж чадахгүй, эмнэлэг байдаг Нохдын талбай дээр тэр хоёр нэлээд удаан явж иржээ. Варя авгайд сандал олж өгч суулгав. Үнэхээр олон хүн байсан учир удаан хүлээлээ. Тэгсээр Софья Александровнагийн ээлж болж, Варя түүнийг даган эмч рүү орлоо.

-Та хэн бэ? гэж эмч асуув.

-Охин нь гэж Варя хариулав.

-Хонгилд байзнаж бай.

-Хүлээгээд суузтаж бай гэж Софья Александровна өгүүлэв.

Эмчид үзүүлсний хэрэг үнэхээр гарсангүй. Тэрээр зүрхний дусал бичиж өгөөд, их хэцүүдвэл нитроглицерин ууж бай хэмээжээ. Эмийн чөлөө ч өгсөнгүй. Софья Александровна Зубовын талбайн тэндэх угаалгын газрын цагаан хэрэглэл хүлээн авагчаар ажилласаар байгаа билээ.

Софья Александровна зовлонтой ажилтай, угаалгын газар үйлч-лүүлэгчдийн цагаан хэрэглэлийг үрэгдүүлнэ, хольж хутгана, цаадуул нь Софья Александровнад л хамаг бухимдлаа гаргана, хөөрхий авгай ядмаг сулхан дуугаар тайлбар тавих бүрий хэлэн дороо үрлээ хийнэ. Ийм л зураг Варягийн нүдэнд тодхон бууна. Нэмэрт нь, угаалгын газрын эрхлэгч Сашагийн тухай, хаанаас ч юм, олж мэдчихээд Софья Александровнаг нүд үзүүлэх болсон төдийгүй, ажилд орохдоо энэ тухай нуусан хэмээн ажлаас халахыг завдсан, даанч ийм цалинтай орон тоонд ажиллах хүн олдоогүй. Ээ дээ бас! Ийм биетэй хүнийг ажилд явуулж болох уу даа? Энэ эмч сохор юм уу, хаашаа юм?

Варя өөрөө ажилтай болохоор Софья Александровнагийн ажилд туслах боломжгүй, гэхдээ гэр орных нь ажлаас хөнгөлөлцөхийг хичээнэ. Тэднийх өөрийнх нь гэр юм шиг санагдах ч нь бий. Өөрийнхөө гэрт л хүн ийм чөлөөтэй, сэтгэл ийм амар байдаг байх. Нэн хачирхалтай нь юу вэ гэхээр, Костя энэ байранд хэзээ ч сууж байгаагүй юм шиг түүнийг санагдуулах юм даанч алга. Энд Софья Александровна л аж төрж байна, үзэгдэхгүй ч гэсэн Саша энд байсаар байна.

Ажил явдлаа амжуулчихаад Варя Михаил Юрьевич дээр орно. Элдэв ном, альбом, хавтас чихээстэй тавиур, шүүгээгээр бараг дүүрсэн өрөө нь гэрэл муутай. Ганцхан ширээ л гэрэлтэй. Ширээн дээр үзэг, харандаа, бийр хийсэн шаазан аяга, шахдаг будаг, цавуу бас хайч, хутга энэ тэр байна. Энэ бол Михаил Юрьевичийн ажлын багаж хэрэгсэл. Варя өндөр аравчтай, цөмөрхий суудалтай хуучин буйдан сандал дээр гараад суучихна.

Будаг, цавуу үнэртээд, гэрийн эрээн хүрэмтэй, хавчдаг шилтэй гоонь эр Михаил Юрьевич нүдэнд дулаахан тухлаг харагдана.

мань хүн ширээн дээрээ тонгойчихсон, нэг хуучирсан номны хуудсыг нааж сууна.

Варя нэг удаа түүний ширээн дээр Сталины боть байхыг хараад гайхжээ.

-Та энүүнийг уншдаг юм уу?

-Унших л болох юм. Ажлаа бодож.

-Ингэхэд та хаана ажилладаг юм бэ?

-Би ЦУНХУ-д ажилладаг.

-ЦУНХУ?.. Тэр чинь юу вэ? Анх удаа сонсож байна гээд Варя инээд алдав.

-ЦУНХУ юу? Центральное управление народно-хозяйственного учёта-Улс ардын аж ахуйн бүртгэлийн төв газар. Хуучин СТГ, Статистикийн төв газар гэж арай зөв нэрлэдэг байсан юм.

Би, Варенька минь, статистикч. Тийм шинжлэх ухааныг мэдэх үү?

-Уйтгартай шинжлэх ухаан байх даа, хаашаа л бол тоо.

-Яалаа гэж дээ. Тооны цаана амьдрал байгаа.

-Би сонин дээр байгаа тоог харахдаа тэр дор нь хаачихдаг юм. Уншихад уйтгартай. Тэгээд дандаа худлаа хэлнэ, бүгд худал тоо.

-Үгүй ээ, тоо чинь тэр болгон худлаа хэлэхгүй, заримдаа бас үнэнийг хэлнэ. За, жишээ нь, энэ байна.

Михаил Юрьевич Сталины ботийн нугалсан хуудсаа нээв.

-Энэ бол нөхөр Сталины ХҮП их хурал дээр тавьсан илтгэл. Нөхөр Сталин 1933 оныг 1929 онтой харьцуулж үзэж байна. Тэгсэн чинь адууны тоо толгой буурсан гарч гээд мань хүн хуруугаа гозойлгон, -34 саяас 17 сая хүртэл, үхрийнх 68 саяас 38 сая хүртэл, хонь, ямааных-147 саяас 50 сая хүртэл, гахайных-21 саяас 12 сая хүртэл тус тус буурчээ гэж давтан өгүүлэв.

-Бүхэлдээ, энэ хэдэн жилд бид 153 сая толгойгоор малаа хорогдуулжээ. Талаас илүү хувийг нь.

-Юу гээч болсон юм бол доо? Үхэл, тахал уу? гэж Варя доогтой асуув.

-Төвөгтэй асуулт. Нөхөр Сталин үүнийг юуны өмнө хамтралжуулах үед нударганчууд малаа их нядласан, бусдыг ч их ятгасан гэдгээр тайлбарлаж байна.

-Нударганчууд аа? Тэр нударганчууд чинь хэд сэн билээ дээ? гэж Варя бас л доогтой сөрж асуув.

-За. Нөхөр Сталины энэ илтгэлд нударганчууд хөдөөгийн хүн амын таван хувийг эзлэж байсан гэж байна.

-Тэгвэл тэр таван хувь чинь манай орны мал сүргийн тал хувийг нядалчихаа юу? Та бас тэгээд үүнд итгэж байгаа юм уу?

-Варенька, итгэж байна гэж би хэлээгүй, чамд нөхөр Сталины хэлсэн үгийг л уншиж өглөө.

-Таны нөхөр Сталин чинь худлаа ярьж байна гэж Варя бухимдав. -Манай байранд Ковровынх гэдэг айл бий, “Красная роза” үйлдвэрт ажилтай, тэд нар хөдөөний улс, тэднийд тосгоныхон ирээд ярьж байхыг маш олон удаа сонссон: Хөхөө өвлийн хүйтэнд хэдхэн хоногийн дотор хүчээр хамтралжуулсан, хашаа хороо ч байхгүй, өвс тэжээл ч байхгүй, гагцхүү “бушуул”, “бушуул” гэж шахсан. Хамаг мал нь эзгүйрсэн, тэд нар шууд тэгж ярьдаг юм. “Гол нь биелэлтийн хувь!..” Биелэлтийн хувь санаснаар нь болж л дээ, харин мал нь үрэн таран болчихож... Хамтралд хөөж оруулаад, малыг нь булаагаад авчихсан болохоор хамтралчдад тэр мал ямар ч падгүй, тэр үхэр, адуу, хонь, гахай чинь хүний юм, үхвэл үхэж л байг гэх шүү дээ.

Таны нөхөр Сталин үүнийг хэлээгүй байна! Мэх, мэх, хаа сайгүй мэх!

Михаил Юрьевич түүн рүү харж бодолхийлснээ,

-Варенька, намайг зөв ойлгоорой. Би таны бухимдлыг ойлгож байна, гэхдээ та амьдарч байгаа цаг үеэ бодолцож байх нь зүйтэй. Бухимдлаа илэрхийлэх чинь аюулгүй биш шүү, орчин тойронд муу хүн маш олон бий, та болгоомжтой байх нь зүйтэй гэв.

-Гэхдээ тантай бол илэн далангүй ярьж болно биз дээ?

Михаил Юрьевич нэлээн түгдэрч байснаа итгэл муутайхан,

-Надтай болно... Харин бидний хоорондоо ярьсан зүйл биднээс

цааш гарахгүй гэж би найдаж байна гэв.

-Юу гэж гарах вэ. Михаил Юрьевич, та надад нээрэн итгэхгүй байна гэж үү?

-Итгэж байна аа, Варенька минь, та шудрага, сайн охин.

-“Охин” гэнэ шүү, би чинь хүнтэй сууж явсан шүү дээ гээд Варя хямсайсхийв.

-Тэр ямар хамаа байна. Миний хувьд бол та охин л юм чинь, Варенька. Тиймээс би айж байна, та дэндүү ил байна, танд хамгаалалт алга, гэтэл алхам тутамд аюул отоож байна, ганц болгоомжгүй хэлсэн үгнээс болж зовлон зүдүүр эдлэж мэднэ, амьдралаа үрж мэднэ. Надаас өөр хүнтэй ийм сэдвээр ярихгүй гэдгээ амлавал сайн байна.

-Би амлая.

-Найдвартай юу?

-Яриангүй.

-Чухам тэгж гэмээ нь л сая миний итгэлийг олно гэдгийг сайн мэдэж аваарай.

-Тэгэлгүй яхав, Михаил Юрьевич.

-Тэгвэл би танд тэр байтугай юм хэлье. Малын тоо толгой хоёр дахин хорогдсон, гэтэл ашиг шим нь 12 дахин буурсан... Нээрэн шүү! 1929 онд махны үйлдвэрлэл 5,8 сая тонн байсан бол 1932 онд дөнгөж 458 мянган тонн. Сүү, цөцгийн тос, ноос, өндөг яг тийм байдалтай. Дэлгүүрт юу ч байхгүйн учир энэ. Москвад ийм байна гээд бод доо! Орон нутагт юу болж байгаа гэж санана. 153 сая толгой мал хорогдуулснаар хөдөө аж ахуй ямар хэмжээний бордоогоо алдсаныг та төсөөлж байна уу, Варя. Зүгээр ч үгүй шим бордоо шүү! Газар тариалангийн хямрал үүнээс үүдэлтэй.

Варя чимээгүй бодлогошрон сууна. Михаил Юрьевич сайн хүн, гэвч одоо бүх хүн нэг янз... Мөн ч болгоомжтой ярьж байна даа... Газар тариалангийн хямрал. Варя жуумалзав.

-Та яагаав, Варенька?

-Яагаав... Та “хямрал”, “бордоо”, “ашиг шим” гэхчилэн ярилаа. Михаил Юрьевич, та намайг уучлаарай, энэ чинь ерөнхий үгнүүд. Гэтэл хөдөө тосгон тосгоноороо өлбөрч үхэж байгааг та мэдэж байгаа, надад Ковровынхан тэгж ярьсан. Би өөрөө ч гэсэн тийм юм энд Москвад, Брянскийн галт тэрэгний буудал дээр үзсэн.

-Тэр буудлыг чинь одоо Киевийнх гэдэг болсон.

-За яахав, Киевийнх болог, ямар ялгаа байна? Би юу харсан гээч, харчуул, хүүхнүүд, хүүхдүүд үхсэн амьд холилдчихсон ундуй сундуй хэвтэж байсан. Украины өлсгөлөнгөөс зулбаж яваа нь тэр юм байж. Гэтэл сэргийлэхийнхэн “Ганган Москва”-гийнхаа царайг сэвтүүлэхгүй хэмээн тэднийг хот руу оруулахгүй, шөнө болонгуут хүүрийг нь зөөж зайлуулна, тэр нь дараачийн хүүрэнд зай чөлөөллөө гэсэн үг... Тийм байхад бид нар хажуугаар нь өнгөрч, галт тэргэнд суугаад найз охидынхоо зуслан руу яваад өгч байгаа юм, бусад хүн ч ялгаагүй, бас л дэргэдүүр нь өнгөрөөд, галт тэргээр зуслан руугаа явцгааж байсан.

-Варенька! Та биднүүс ер яах сан билээ?

-Юу?! Хачин асуулт байна! Би нэг юмнаас уншсан: Хувьсгалаас өмнө нэг өлсгөлөнгийн үеэр, хэдэн онд билээ дээ...

-1890-ээд оны эхээр өлсгөлөн болсон гэж Михаил Юрьевич өгүүлэв.

-Тэр өлсгөлөнгийн чинь үеэр хүмүүс мөнгө цуглуулж, үнэгүй хооллох гуанз зохион байгуулж байсан байна лээ. Лев Николаевич Толстой өлсгөлөн хүүхдийн гуанзанд байж байгаа нэг гэрэл зургийг би бас, хаа ч билээ, харсан... Би бас нэг юм санаж байна, би жаахан байсан л даа, манай эгч Нина, Саша Панкратов, Максим Костин энэ тэр бусад хүүхдийн хамт сэнжтэй аяга барьчихаад, Ижил мөрний өлсгөлөнчүүдэд зориулан өглөг цуглуулж байсан, тэгэхэд тэнд өлсгөлөн болж байгааг нуулгүй туслацгааж байсан.

Михаил Юрьевич,

-Тэгэхэд Ленин байж шүү дээ гэв.

-Харин тийм ээ гэж Варя түүний үгийг өлгөж авав. -Одоо яаж байна: “Аз жаргалтай амьдралынхаа төлөө нөхөр Сталинд баярлалаа”. Гадаа гудамжинд биш, галт тэрэгний буудал дотор үхэх эрх олгосонд нь түүнд баярлах байх. Хичнээн хонь, гахай үхсэнийг нөхөр Сталин ил хэлж байна, харин хэдэн хүн үхсэнийг хэл лүү?

-Илтгэлд тэр тухай байхгүй хэмээн Михаил Юрьевич үнэнийг хүлээв.

-Тэр харахгүй юу, гахайны тухай хэлчихээд, хүний тухай хэлээгүй байна гэж Варя бах нь ханаж өгүүлэв. -Гахайг муусайн эсэргүүнүүд, муусайн нударганчууд нядалчихсан гээд тэдэн рүү чихчихнэ, харин хүнийг яаж тэдэн рүү чихэх вэ, өөрөө л хүлээх ёстой доо. Михаил Юрьевич, та статистикч хүн, хамтралжуулалтын үеэр манай оронд хичнээн хүн үхсэн бэ?

-Хэлэхэд хэцүү... Албан ёсны ямар ч тоо байхгүй, ер нь хэзээ ч гарахгүй, үхсэн хүнийг тоолдоггүй юм чинь. Өлсгөлөнтэй бүсийг улс орны бусад нутгаас зүгээр л тусгаарлалчихсан.

-Статистикийн та нар бодоод гаргачихаж чаддаггүй юм уу? Статистикийг шинжлэх ухаан гэж та хэлээ биз дээ.

-Статистик ч шинжлэх ухаан л даа. Тийм учраас албан ёсны эх сурвалжийн далдалж байгаа зүйлийг энэ ухаанаар яггүй тодорхой тооцоолж болно.

-Тэгээд ямаршуухан дүн гарч байна?

-Ийм л дээ... 1933 оны эхэнд манай орны хүн ам 165,7 сая байсан. Гэтэл ХҮШ их хурал дээр гээд Михаил Юрьевич номоо тогшиж, -1934 оны нэгдүгээр сард нөхөр Сталин 1933 оны эцэст манай хүн ам 168 сая хүрсэн гэж мэдэгдсэн. Энэ тоог манай статистикийнхан нөхөр Сталинд өгөөгүй, 1933 онд хүн 2,3 саяар өссөн мэт ярина гэдэг бол худлаа хэлж байна гэсэн үг, бид нар бүр айдаст автсан шүү. 1933 онд эсрэг юм болсон, хүн ам буурсан, өлсгөлөн бас үхлийн хувь өндөр, ялангуяа хүүхдийн үхэл их өндөр хувьтай байсан. хүнсний хангамж овоо дээр байсан хотуудад хүртэл төрөлтийн тоо үхлийн тооноос бага байсан.

Хаалганы цаана хөрш Галягийн дуу хадлаа:

-Михаил Юрьевич, танай данх буцалчихлаа.

Варя бослоо.

-Би унтраачихъя. Танд цай хандалж өгөх юм уу?

-Хэрэггүй ээ, баярлалаа, би цай уумааргүй байна. Үнэнийг хэлэхэд, данхаа таг мартчихаж... Харин та өөрөө цай уух юм уу?

-Би Софья Александровнагийн цай уучихсан.

Варя гал тогоо руу очиж ирээд дахиад сандал дээр гарч суув.

-За тэгэхээр, нөхөр Сталиных яагаад 168 сая болчихов? Би танд тайлбарлая. Хориод оны хоёрдугаар хагаст, шинэ эдийн засгийн бодлогоор амьдралын түвшин дээшлэх үед хүн ам жилд дунджаар 3 саяар нэмэгдэж байсан юм. Нөхөр Сталин өсөлтийн энэ тоог 30-аад оны эх рүү тэр чигээр нь шилжүүлсэн. түүний тооцоо маш энгүүн: хүн амын сүүлчийн тооллого 1926 онд болсон, тэгэхэд 147 сая хүн тоологдсон. Долоон жил өнгөрч. Долоог гурваар үржүүлэхээр 21, 147 дээр 21-ийг нэмээд тэнцэх нь 168 сая. Нөхөр Сталины статистик энэ дээ. түүнээс хойш үүнийгээ зүтгүүлсээр ирсэн. Энэ жил, бүр саяхан Тэрээр манай хүн ам жил бүр “бүхэл бүтэн финляндаар” нэмэгдэж байгаа тухай ярина лээ. Гэхдээ энэ тийм биш гэдгийг бүгд чимээгүй хүлээн зөвшөөрч байгаа. 1937 оны эхээр хүн амын шинэ тооллого болно, статистикчид ч, засгийн газар ч 170 саяын баримжаанд дүн гарна гэж хүлээж байна. За тийм болно гэж саная. Тэгвэл юу гэсэн үг вэ? Давтан хэлэхэд, 26 онд манай хүн ам 147 сая байсан. Өсөлтийн хэвийн тоо 3 сая. Тэгвэл 1937 онд хүн амын тоо 177 сая байх ёстой. Гэтэл

манай удирдагчид хамгийн дээд тал нь 170 сая гэж хүлээж байна. 7 сая хүн хаачив, тэд хаашаа алга болчихов? Варя, би бол туршлагатай статистикч, 1937 оны тооллогоор 170 сая ч хүрэхгүй гэдгийг хэлье. Миний тооцоолсноор бол хамгийн дээд тоо 164 сая. Тэгвэл шууд буюу дам хорогдол наад зах нь 13 сая болно. Энэ бол өлсгөлөнгөөр үхэгсэд, нударганчуудтай тэмцэх үед амь үрэгдэгсэд, төрөлт буурсны хорогдол.

-13 сая, ямар аймаар юм бэ? гэж Варя бодлогошрон өгүүлэв. - Орос улс тэгвэл дэлхийн дайнд хичнээнийг алдсан юм бол?

-Бүтэн хагас сая.

-Дэлхийн дайны явцад бүтэн хагас сая, хамтралжуулах явцад арван гурван сая. Тэр бүтэн хагас саяын төлөөсөнд хааныг ширээнээс нь авч хаясан, гэтэл энэ арван гурван саяын хариуд “Аз жаргалтай амьдралынхаа төлөө нөхөр Сталинд баярлалаа!..” гэж хашгиралдаж байна. Тэглээ ч гэсэн тэд чухам яагаад үхсэнийг ойлгохгүй юм. Мал, яахав, үхэж. Гэтэл тариа тариад, хурааж аваад байсан биз дээ.

-Тариа байгаагүй гээд Михаил Юрьевич царай нь барайв. Сталин энэ илтгэлдээ 1933 онд бид 89,8 сая тонн үр тариа хурааж авсан гэж нотлож байна. Энэ бол худлаа. Бид дөнгөж 68,4 сая тонн буюу Сталины хэлж буйгаас 21 саяар бага, хамтралын өмнөх буюу 1927-29 оныхоос бол бүр хамаагүй бага ургац авсан. түүнээс гадна 1933 онд хотын хүн 12 саяар нэмэгдсэн. Хотын хүн ам үр тариа үйлдвэрлэхгүй, гэтэл өөрсдийг нь тэжээх хэрэгтэй. Тэжээсэн ч. 1927-29 онд ургацтай жилүүд таарч гадаадад 2,5 сая тонн үр тариа гаргасан, гэтэл 1930-32 оны ургац муутай жилүүдэд бараг 12 сая тонныг гаргасан. Манай улс хэзээ ч ийм их үр тариа гаргаж байгаагүй.

-Хүмүүс өлсөж үхэж байхад үр тариагаа гадагш нь гаргаад байжээ дээ?!

-Тийм. Өрнөдийн техник худалдаж авахад валют хэрэгтэй. Үйлдвэржүүлэлт!

-Тариачдын үр тариаг шууд булааж авч байсан гэж би дуулсан, сэргийлэх, цэргийн анги, нэгдсэн улс төрийн газрынхан хүчээр авдаг, тариагаа тушаагаагүй тариачинг ажил боогдуулагч хэмээн шүүж, хөрөнгийг нь хурааж, цөлдөг байсан гэсэн.

Тэр хоёр чимээгүй болцгоов. Тэгж байснаа Михаил Юрьевич,

-Атга буудай үлдээлгүй хурааж, өлсөж үхэхээс өөр замгүй болгож байсан даа... Энэ тухайд Варя, таны зөв шүү... гэв. -Нударганчуудыг яасан билээ?

Нударганчууд төдийгүй дундчууд, тэр ч байтугай ядуучуудын хөрөнгийг хураасан. Ядуучуудыг “нударганчуудын гар, хөл бологчид” гэж утгагүй нэрлэснийг яана. Миний их дарсан тооцоогоор бол наад зах нь арван сая хүний хөрөнгийг хураасан, наад зах нь шүү. Тэдний дийлэнхийг Сибирь, Умард руу цөлсөн. Тэднээс маш олон хүн амь алдсан нь мэдээж.

-Ёстой аймшигтай юм аа. Ард түмнээс хуу нуухыг яана гэж Варя зэвүүцэв.

-Үгүй ер, та яалгах гэсэн сэн бол? гээд Михаил Юрьевич инээмсэглэн цавуугаа авлаа.

-Үйлдвэржүүлэлтийг чинь ийм хохиролгүй хийж үнэхээр бол-доггүй юм байх даа?

-Болно л гэж бодогдох юм. Дэлхийн дайн, иргэний дайны дараачаар 1922 он гэхэд улс орон сүйрч хоосорсон байсан. Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг үрэн таран хийж, хоосон байр л үлдсэн. Тэгтэл тавхан жилд, 1927-29 онд бүгдийг нь сэргээсэн, элдэв өлсгөлөн, цөллөг, буудлагагүйгээр аж үйлдвэр, хөдөө аж ахуй, тээвэр гэхчилэн бүгд нурман дээрээс сэргэсэн. Шинэ эдийн засгийн бодлогын ач тэр. Гэтэл одоо нөхцөл байдал өөрчлөгджээ. Энэ бол том бодлогын асуудал гэснээ Михаил Юрьевич Варя руу харж, -Харин энэ тоонуудыг та нэг их дурдаад байхын хэрэггүй шүү гэв.

-Яагаад? Нөхөр Сталин хэлсэн тоонууд шүү дээ.

-Нөхөр Сталин илтгэлдээ зөвхөн малын толгой хорогдсон тухай л хэлсэн. хүний хорогдлын тухай юу ч хэлээгүй. Энэ бол миний, хувийн гэх үү, тооцоо. Тиймээс үүнийг мартчих, хаа ч битгий дурсаарай.

- Михаил Юрьевич та санаа зоволтгүй, таны тооцоог би хэнд ч ярихгүй. Одоо ингээд мартлаа. Гүйцээ! Би гагцхүү нөхөр Сталины ярьсан юмыг, малын тоо толгой буурсныг л ярьж байя.

-Тэр тухай ч бас ярих хэрэггүй.

-Яагаад? Энэ тухай Сталин өөрөө ярьсан шүү дээ.

-Сталины ярьдаг юм дуртай хүн болгоны уншлага биш. Дутагдалтай тэмцэхийн тулд Сталин тоо хэлж байгаа юм. Гэтэл тэр тоог та хэлэх юм бол дутагдлыг бах болгосон болчихно. Нөхөр Сталин түүний зэрэгцээ бусад салбарын аугаа их амжилтуудын тухай ярьсан байгаа, та бол тэр сэдвийг хөндөхгүй гэж би ойлгож байна, тэгэхээр таныг өрөөсгөл хандлаа гэж буруутгана.

-Нөхөр Сталин өрөөсгөл яриагүй юу?

-Та юуг хэлж байна?

-Үхэр, адууны тухай ярьчихаад хүний тухай яриагүй! Арван гурван саяар их ч байсан яалаа, бага ч байсан яалаа! Мажийцгааж, тэгээд юу гэж! Ингэж сэтгэж байх нь.

Михаил Юрьевич багаж хэрэгслээ эмхэлж, сонинтой хавтсаа үдээд, Варя руу санаа зовнингүй харав.

-Бид хүнд бэрх цагт, бүр хэрцгий догшин цаг үед аж төрж байна. Төрөх өдөр, сар, жилээ өөрснөө сонгох биш, бид Оросын түүхийн их эргэлтийн үед таарчээ. Тэгэхээр цаг үеэ харгалзах нь алба. Гэхдээ энэ бол бид аялдан дагах, худлаа ярих, хуншгүй зан гаргаж урваж хөрвөх ёстой гэсэн үг биш, энэ бол бид болгоомжтой байх ёстой, өөртөө болон ойр дотныхондоо балаг тарих юм ярих ёсгүй гэсэн үг. Саша муу хүн үү, шууд хэлэхэд, манай зөвлөлтийн хүн биш үү? Гэтэл түүнийг яав? Ханын сонинд шалихгүй зүггүйтсэний төлөө,

нягтлан бодохын бил үү, багштай маргасан төдийгийн төлөө. Тийм сонин гаргахгүй, тэр багштай маргахгүй тэгсэн хэрнээ үнэнч шудрага хэвээрээ байж болох л байсан. Та ч ялгаагүй. Ийм яриа дэлгээд байвал таны амьдралыг ч Сашагийнх шиг үрэн таран хийнэ, одоо бол гуравхан жилийн цөллөгөөр тогтохгүй. Одоо ялын хэмжээ, хугацаа өөр болсон. Тийм учраас л би таныг болгоомжтой байгаарай гээд байна, Варенька минь.

Варя дуугарсангүй. Михаил Юрьевичийн зөв л дөө, мань хүн өөрийнхөө өмнөөс, бас түүний өмнөөс айж байна, айдас бүхнийг эзэмджээ. Тэгвэл ёс суртахуун, зан суртахууны тухай мундаг юм ярихын хэрэг алга. Яагаад гэвэл үнэнийг ярихаас айна гэдэг ёс суртахуунгүй явдал.

Хэдийгээр Михаил Юрьевичтэй маргамааргүй байвч Варя тэссэнгүй,

- Михаил Юрьевич, бид ёс суртахуун, зан суртахууны зарчимд тэрслэх ёсгүй гэж та сая хэллээ. Гэтэл дэргэд хүн өлсөж үхээд байхад бид туслахгүйгээр барахгүй, юу ч болоогүй юм шиг царайлаад дуугүй байгаа маань ёс суртахуунтай, зан суртахуунтай хэрэг үү?

Михаил Юрьевич хавчдаг шилээ авч зөөлөн даавууны өөдсөөр арчив. Ойрын хараа муутай хүмүүс шилээ авчихаар ийм л мэгдсэн арчаагүй харцтай болчихдог доо. Варя түүнийг өрөвдөв.

- Михаил Юрьевич, би таныг гомдоох гээгүй шүү, гомдоосон бол өршөөгөөрэй. Надад юмны учрыг өөрөө ойлгож авах нь чухал байна. Ингээд бодохоор, муу юм хийх хэрэггүй, сайн юм хийж болохгүй гэсэн дүгнэлт гараад байх шиг. Арай ч биш юм аа, сайн юм хийж болно, гэхдээ хаяагаа манаж, тэр нь өөрт л аюулгүй бол хийж болох нь.

Михаил Юрьевич түүн рүү харав.

-Үгүй ээ, та намайг буруу ойлгож. Сайн үйлс бүтээх хэрэгцээ бурхны ачаар, хүнд үүрд заяагдсан зүйл, тиймээс сайн юм хийх хэрэгтэй, тэр ч атугай, хаяа манах энэ тэр гэлгүй хийх хэрэгтэй. Би танаас өөр юм уриалж байна: б у р а х г ү й б а й х ы г. Улс төрөөс холхон бай, Варя, эс тэгвэл юу болдгийг та харж байна. Хувьсгал хийсэн, төр барилцаж байсан хүмүүсийг алуурчин, алан хядагч, тагнуул хэмээн шүүж, буудан хөнөөж байна. Ийм юмнаас холхон яв, Варя. Та ажил, хичээлдээ дуртай, түүндээ л явж бай. Бусад бүх юм танд зохихгүй.

Сталин өрөөн дотуураа холхино. Ягода, Ежов хоёр ширээний эсрэг талаас өөд өөдөөсөө хараад сууж байна.

Ежовын өмнө урьдын адил том дэвтэр байна. Ягодын өмнө дэвтэр алга, Тэрээр хэзээ ч, юу ч тэмдэглэж авахгүй, гагцхүү тогтоож авна.

Сталин Ягодын баргар царай руу жишүүхэн харж, чимээгүй холхино. Цаадах нь Ежовыг энд байгаад дургүй буй хэрэг. Яагаад дургүй байна вэ? Ежов одоо захиргааны байгууллагууд, түүний дотор ДЯАК-ыг хариуцсан ТХ-ны нарийн бичгийн дарга. Нэмэрт нь, Намын хянан шалгах комиссын дарга болохоор Ягодад өгч буй намын даалгаврыг бүрэн мэдэж байх ёстой хүн. Түүгээр зогсохгүй Ежов энэ даалгаврын биелэлтийг хянах болно.

Ягода мань хүн өөртэй нь ганцаарчлан уулзаж ярилцдагт дасчээ. Тэрээр түүний х а м с а а т а н байхыг горилно. Харин түүнд хамсаатан хэрэггүй, гүйцэтгэгч л хэрэгтэй, түүний заалт бол намын заалт, тийм учраас л намын ТХ-ны нарийн бичгийн дарга Ежовын нүүрэн дээр өгөгдөж байна.

-Зиновьев, Каменев хоёр есөн жил нүглээ наманчилж, өөрсөд рүүгээ угаадас цацаж, өршөөл гуйж байна хэмээн Сталин сая ам нээв. -Тэд нар Кировын алагдсаны ёс суртахууны хариуцлагыг өөр дээрээ хүлээж, түүний учир шийтгүүлсэн. Яагаад хүлээв? Яах гэж хүлээв? Амиа авч үлдэх гэж. Тийм замаар жинхэнэ хариуцлагаас мултрах гэж шийдсэн хэрэг. Тэд өөрсдийгөө л бодож. Намын тухай бодсонгүй, ер нь хэзээ ч бодож байгаагүй, тэд нар зөвхөн даагаа нэхэх цагийн тухай туж бодож ирсэн. Тэгнэ байх аа! Тэд далд санаагаа онхиос орхих ёстой, э ц с и й н э ц э с т намдаа жинхэнэ ёсоор туслах ёстой.

Тэрээр холхисон чигээрээ чимээгүй болзнов. Тэгсхийгээд дахиад ярьж эхлэв.

-Өнөөгийн олон улсын нөхцөлд пролетарийн бүх хүчнийг улс орны дотоодод төдийгүй, түүний гадна ч нэгтгэж нягтруулах шаардлагатай. Үүнд хэн саад хийж байна? Тэд нар байнга саад хийсээр ирсэн, одоо ч хийж байна. Гэтэл социалистуудын толгойлогчид социал-демократ маягийн намаа социал-фашист нам болгон хувиргаж, фашизмтай улам бүр сүлбэлдэж байна. Ийм нөхцөлд ухамсар сайтай ажилчид социалистуудаас хөндийрөх нь зайлшгүй. Тэд нар манай зүгт, бидэн рүү урагшлах ёстой. Тэдний мөр дээр хэн байна? Тэдний мөр дээр Троцкий, троцкийчууд, троцкизм зогсож байна. Троцкий Үү Интернационал байгуулахыг санаархаж, манай нам, манай оронд дайсагнасан хүчээр өөрийгөө хүрээлүүлж, биднийг гүжирдэж элдэв новшоор булж, зүүн тийшлэж буй ажилчин-социалистууд, тэргүүний сэхээтнүүд, колонийн орнуудын ардын чөлөөлөх хөдөлгөөнийг биднээс хөндийрүүлж байна. Энэ хэнд ашигтай вэ? Энэ бол англи, францын империализмд, германы фа-шизмд, японы милитаризмд л ашигтай. Олон улсын пролетариудын нягтрал тэдний дайсагнасан төлөвлөгөөг таслана, нөгөө талаас, олон улсын пролетариудын задрал тэр төлөвлөгөөнд дэм болно. Троцкий хэний тулд ажиллаж байгаа нь энэ. Тэр бүх насаараа большевик намтай тэмцэж ирсэн, одоо ч тэмцэж байна. Бас нам ч бүхий л түүхээрээ Троцкийтэй тэмцэж ирсэн, одоо ч тэмцэх болно. Энэ тэмцэлд Зиновьев, Каменев хоёр

туслаг, намд чин үнэнч гэдгээ эцсийн эцэст амаар бус ажлаараа харуулаг, намын өмнө бүрэн дүүрэн гэмшсэн гэдгээ ажлаараа харуулаг.

Сталин үгээ таслаж, дахиад өрөөн дотуураа холхив. Ягода, Ежов хоёр ч дуугарсангүй.

-Кировыг алсан нь хэнд ашигтай болж таарав? Троцкийд, түүнийг талархагчдад. Кировыг алах нь хэнд хэрэгтэй байв? Троцкийд, түүнийг талархагчдад. Энэ яагаад тэдэнд хэрэгтэй вэ, энэ яагаад Троцкийд ашигтай вэ? Хоёр шалтгаанаар энэ түүнд хэрэгтэй, энэ түүнд ашигтай. Нэгд, Зөвлөлтийн дотоод байдал хэврэг байгааг дэлхий нийтэд харуулах, японы милитаристууд, германы фашистууд, англи, францын империалистуудыг сэргээх. Хоёрт, ЗСБНХУ-ын дотоодын хувьсгалын эсэргүүг алан хядлагын замд оруулах. Кировыг алснаар Троцкий ЗСБНХУ-д хувь хүний алан хядлагыг дэгдээж байна. Тийм учраас бид Троцкий ЗСБНХУ-д алан хядлагыг зохион байгуулагч, Кировын аллагыг зохион байгуулагч, нам, засгийн удирдагчдын эсрэг алан хядах ажиллагаа бэлтгэж байсан алан хядагчийн бүлгийг ЗСБНХУ-д байгуулагч, фашизм, милитаризм, империализмын холбоотон гэдгийг дэлхий дахинд илчлэн харуулах ёстой. Тэгэхээр Зиновьев, Каменев түүнчлэн тэдний талынхан. Троцкий Кировын аллагын зохион байгуулагч, Зөвлөлт засгийн эсрэг, зөвлөлт засгийн удирдагчдын эсрэг алан хядлагыг зоригжуулан зохион байгуулагч гэдгийг илчилж өгөг. Тэднээс олон зүйл шаардахгүй. Троцкий Кировыг алахыг тушаасан, нам, засгийн удирдагчдын эсрэг алан хядлага бэлтгэхийг тушаасан гэдгийг л хүлээхэд болоо. хэнд тушаагаа вэ? Тэдний байгууллагад. Троцкий-чууд, зиновьевчуудын нэгдсэн байгууллагад. түүнийг, жишээ нь, “Нэгдсэн төв” гээд нэрлэчихье... Аятайхан нэр. Ленинградад “Ленинградын төв” гэж байсан, тэгвэл энэ “Нэгдсэн төв” болог, троцкийчууд, зиновьевчууд нэгдсэн, Троцкийд захирагддаг төв.

Ежов дэвтэртээ нэг юм тэмдэглэв. Сталин түүн рүү хялайснаа хараагаа шилжүүлж цааш нь үргэлжлүүлэв.

-Зиновьев, Каменев хоёрын мэдүүлгийг үнэмшилтэй, жинтэй болгохын тулд яллагдагсадын суудалд троцкийчуудыг бас хамт суулгах хэрэгтэй. Троцкийчууд хичнээн олон байна, төчнөөн сайн. Бас тэр троцкийчууд хичнээн алдартай, хичнээн торниун байх тусмаа төчнөөн сайн. Тийм троцкийчуудыг олоход төвөгтэй биш гэж би бодож байна. Шорон, хорихуудаар тэд нар олон бий. жинхэнэ троцкийчуудыг шүүхэд татвал Зиновьев, Каменев хоёрын байдлыг хөнгөлж өгнө. Троцкий руу хамаг юмаа чихэг, түүнийг л зүхэж байг. Троцкий манай улсын заналт дайсан гэдгийг бүгд мэднэ, аль эртнээс мэднэ. Нэгдүгээр сарын шүүх ажиллагаан дээр тэр хоёр Кировыг алуулсны ёс суртахууны хариуцлагыг хүлээсэн. Гэтэл тэд бол маркесчид, ёс суртахууны хариуцлага, жинхэнэ хариуцлага хоёрын ялгаа юу байна? Ялгааг би олж харахгүй байна...

Тэрээр дахиад нэгэнтээ нааш цааш чимээгүй холхисноо үргэлжлүүлэв.

-Жинхэнэ троцкийчуудыг нугалах бол, мэдээж, хэцүү байх болно. Тэд бол чанга ардууд. Зиновьев, Каменев хоёр шиг олон жил худлаа гэмшиж, хэнхдэг цээжээ дэлдэж яваагүй, буруугаа ч хүлээж байгаагүй хүмүүс. Нэмэрт нь олон жил шорон, хориход сууцгааж байгаа, хэрэгт холбогдолгүй гэдгээ чухамхүү шорон, хорихоор л нотлох гэж үзнэ. Ямар ч шорон, ямар ч хорих хэрэгт холбогдолгүйн баталгаа болж чадахгүй. Хувьсгалт хөдөлгөөний, бас

хувьсгалын эсэргүү хөдөлгөөний туршлагаас үзвэл шоронд сууж байгаад хувьсгалт эсвэл нөгөө талд нь, хувьсгалын эсэргүү ажилд дажгүй оролцож болно, өөрийнхөө талынханд удирдамж чиглэл өгч болно, удирдагчидтайгаа захидлаар харилцаад байж болно.

Ягодын царай үл мэдэг татавсхийсэн боловч Сталин анзаарчихав... Ягода санал нийлэхгүй байна. Хуучин хаант засгийн шоронг өнөөгийн ялаа ч нэвтрэхийн аргагүй шоронтой яаж зүйрлэх вэ гэж буй... Ягода харьяа газраа мэднэ ч, хариуцна ч гэж буй... Гэтэл нөхөр Сталин мэдэхгүй, хуучнаараа төсөөлж байна гэж буй...

Сталин Ягода руу харж, тулгасан янзтай давтан хэлэв:

-Захидлаар харилцаж болно. Бүрэн болно. Тэгж яривал харилцаад байгаа шүү дээ гэв.

Ежов хичээнгүйлэн тэмдэглэж авч байна.

-За тэгэхээр, та нар шорон, хорихоос хэдэн зуун троцкийчуудыг авчирвал тэдний дундаас намын эсрэг тэмцээд ямар ч ирээдүйгүйгээ ойлгож, Троцкий тэднийг ямар намаг руу татаж оруулсныг ойлгож, шудрагаар хэргээ хүлээн энэ намгаас гаръя гэх хорь, гучин хүн та нар олно. Мэдээж, амаргүй зорилт. Гэвч ДЯАК-т хөнгөн зорилт гэж ерөөсөө байхгүй. Дайсантай тэмцэх бол хүнд боловч нэр төртэй ажил. Чекистүүд энэ зорилтыг биелүүлэхдээ намын хариуцлагатай даалгаврыг биелүүлж байна гэдгээ ойлгох ёстой.

Тэрээр Ягодын өмнө тулж ирээд зугуухан хэрнээ нухацтай үргэлжлүүлэв:

-Зөвлөлт Холбоот Улсын эсрэг Троцкий цагаандаа гарсан хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байгаа тухай няцаагдашгүй нотолгоо намд бий. Мөрдөн байцаах байгууллагад ганцхан зүйл үлдэж байна: “Нэгдсэн төв”-д оролцогчдоор алан хядах үйл ажиллагаанд, тухайлбал, нөхөр Кировын аллагад оролцсоныг тулган хүлээлгэх... гээд Ягодаг муухай харсан чигээрээ азнасхийв. -Тэд хэргээ хүлээхгүй байж чадахгүй, хэрэг нь баримтад тохирч байгаа юм чинь. Баримтыг хүлээн зөвшөөрөхгүй бол тэдэнд л их хүнд уршигтай юм болно доо.

Ягода, Ежов хоёр өрөөнөөс гарав.

Сталин ганцаараа үлдлээ.

Ежовыг байлцуулсанд Ягода дургүй байгаа нь тохиолдлын зүйл биш. Энэ дургүйцлийн цаана ердийн өрсөлдөөнөөс арай дүнтэй юм бий. Тэрээр түүнийг хамсаатан гэж үзэхгүй байгааг ойлгочихож. түүнд хамсаатан биш, гүйцэтгэгчид хэрэгтэйг ойлгочихож. Өөрийнхөө бүх үйлдлийг өөрөө хариуцах нь, түүнтэй хэн ч хариуцлага хуваалцахгүй нь гэдгийг ойлгочихож.

Ягода өнөөдөр анх удаа ингээгүй, бас ганцхан удаа ч ингэж байгаа бус. Медведь, Запорожец хоёрт талтайгаа нуухгүй байгаа. Тэднийг ялтны вагоноор биш, шууд очих тусгай вагоноор явуулсан. Явуулахын өмнө дуудаж ярилцсан.

Яах гэж дуудав, юун тухай ярилцав?

Тайвшруулаа л даа. За, нөхдүүд минь, тэсзнээрэй, учир нь олдоно, маний буруугаар биш шүү,

ийм л юм болчихлоо. ТЭР л ингэж тулгасан юм, харин бид та нарыг гомдоохгүй гэх маягийн юм хэлээ биз.

Медведийн авгайд нөхөр рүүгээ ирж очихыг яагаад зөвшөөрч байна? Яагаад бүхний нүдэн дээр ингэж байна?

ДЯАК-ын тээврийн хэлтсийн дарга Шанин Запорожецэд эртний орос дууны хоёр хэсэг пянз явуулсан. Яах гэж явуулав? Зовлонд унасан нөхрөө тайтгаруулж байна уу? Запорожец тэнд энэ пянзгүй аж төрж чадахгүй байх нь уу?

ӨӨРИЙНХ нь, нөхөр Сталины хувийн хамгаалалтын албаны дарга Паукер, Будапештийн үсчин явсан нэг муу хулчгар, марзан толгой хүртэл Запорожецэд радио хүлээн авагч явуулсан байгаа юм даа. Чулуун зүрх гаргажээ. Манай муу Ваня зүв зүгээр байж байгаад авахуулчихлаа гэж өрөвдөж, харамсаж байх нь. Т э д н и й ажил дээр өрөвдөх зүгийн юм юу ч байх ёсгүй.

Энэ бүх үйлдэл бол ДЯАК-ын ажилтнууд бүхнийг мэднэ, өөрсдийнхнийгээ гомдоолгохгүй гэдгээ харуулах, тэд нар хүчтэй, хаа ч байсан бие биенээ харж үзнэ гэдгээ түүнд харуулах гэснийх. Улс төрийн Товчооны гишүүнийг хамгаалж байж чадаагүй Медведь Запорожец хоёрыг мань хүн яаж ч чадах байсныг үнэхээр ойлгохгүй байна гэж үү?

Буудан алах ял өгч чадах байлаа.

Тэгэх ч хэрэгтэй байж.

Гэтэл мань хүн тэднийг удирдах ажилд явуулсан, хэрэг дээрээ сувилалын газар явуулсан, нэгийг нь хоёр жилээр, нөгөөг нь гурван жилээр. Тэгээд л тэднийхэн тэр хоёрыг түүний хамсагч, мань хүн тэр хоёроос айж байна, мань хүн тэдний гарт байна гээд бодчихож. Тиймээс өөрсдийн хүч чадал, бие даасан байдлыг үзүүлж байгаа ухаантай юм. Энэ бол хуйвалдааны үр хөврөл, шинэ, “чекистийн хуйвалдааны” үр хөврөл.

Ягода, ДЯАК-ын аппарат хоёр түүний хүсэл зоригийг л биелүүлж байна. Одоохондоо. Зөвхөн одоохондоо. Тийм учраас Ягода, түүний аппарат хоёрыг сольж таарна.

Гэхдээ тэднийг одоо солиход эрт байна. Зиновьев, Каменев хоёрыг эхлээд гүйцээж цохиг, тэд үүнийг эхлэхсэн, тэд үүнийг чадна.

Яг шүүн таслах ажиллагааг Вышинский явуулна. Тэр муу үүнийг чадна. Энэ хооронд Ежов ДЯАК-ыг хариуцсан ТХ-ны нарийн бичгийн даргын хувьд тэндхийн ажлыг мэдэж аваад, шүүх ажиллагааны яг дараачаар Ягодын оронд очно, түүний аппаратыг солих хүмүүсээ өөрөө аваачна.

Эсэргүүцэл үзүүлэх үү? Эргэлзээтэй. Цохилт гэнэтхэн бууна. Цаана нь бас тэнцүүлэг бий. Арми.

Түр зуурын тэнцүүлэг, гэхдээ одоохондоо ямар ч атугай тэнцүүлэг.

Арми хэзээ ч найдвартай байдаггүй. Хормын төдий сонор сэрэмжээ сулруулах юм бол,

жолоог нь мэдэгдэх төдий сулруулах юм бол ямар ч арми найдваргүй. Ордны бүх эргэлтийг арми, тодруулбал армийн толгойлогчид хийж байсан. Зөвхөн Октябрийн хувьсгал л армийн толгойлогчдод тулгуурлаагүй, харин цэргийн олон түмэнд түшиглэсэн, зэвсэг тэдний гарт байсан шүү дээ.

Өнөөгийн цэргийн боловсон хүчнүүд ДЯАК-ын боловсон хүч-нүүдээс найдвар муутай. Троцкийн талын олон хүн тэдний дунд нуугдаж байгаа. Өөрснийгөө иргэний дайны баатрууд гэнэ. Нөхөр Сталины иргэний дайнд гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдлыг үгүйсгэж, түүнийг үзэн ядна.

Шмидт гэж нэг увайгүй новш, хүний адгийг бодохтойгоо зэрэг одоо ч гэсэн түүний хамаг дотор нь эргэчих шиг болно. Тэр Шмидт ХУ их хурал дээр сөрөг хүчнийг дэмжиж байсан билээ. Санал шүүмжлэлийн дараа түүнийг Кремлиэс гарч явахад хүрч ирээд тоглоом шоглоомоор түүн рүү баахан хуарангийн хараал урсгасан юм.

Одоо тэр Шмидт Якирын удирдлага дор танкийн бригад командалж яваа. Якирын найз. Якир бол Тухачевскийн чин үнэнч журмын нөхөр.

Тухачевский, түүний хамтран зүтгэгчид 1920 онд Варшавын хаяанд ялагдсанаа хэзээ ч мартаггүй. Тэр ялагдлаа Сталин руу чихэх гэж үзэв дээ. Ленин хүртэл “Львовоор дайрч Варшав ордог хүн гэж байх уу даа?” гэж егөөдөж тэднийг дам дэмжиж байсан.

Ер нь Ленин хэзээний дэндүү итгэмхий болохоор Тухачевскийг хувьсгалын хэрэгт үнэнч, шулуун шудрага цэргийн мэргэжилтэн гэж боддог байсан. Валериан Куйбышевийн үгэнд орж тэр л дээ. Куйбышев Тухачевскийтэй хамт сурч байсан дүүгийнхээ үгээр үг хийсэн хэрэг.

Бас Троцкий, мэдээж, Тухачевскийг дэмжсэн, түүний мөрөн дээр суугаад Берлин орчихно гэж бодохгүй юу.

Одоо Тухачевский ном бичиж байгаа, цэргийн шинжлэх ухаан руу орсон нэрийдлээр чимээгүй хярчихаад байна. Хэзээ ч, ямар ч сөрөг хүчинтэй нийлж байгаагүй, өөрөөсөө өөр хэнд ч найддаггүй, зөвхөн ө ө р и й н замаар явж ирсэн, улс төрийн элдэв явуулга, гэдсэндээ хөлөө хийлцэхээс жигшдэг, хэрэгтэй цагт улс оронд дэг журам тогтоож чадах биеэ даасан цэргийн мэргэжилтэн юм гэнэ. Хэрвээ шаардлагатай бол хувьсгалын эрхэм зорилгыг диктатураас аврана, өөрөөр хэлбэл, Зөвлөлт засгийг түүний, Сталины гараас аврах юм гэнэ. Энэ бол түүний эцсийн зорилго, түүний гол зорилт!

Армийн улс төрийн газрууд ч бас найдваргүй, тэнд командын бүрэлдэхүүнийг бодвол троцкийчууд илүү олон байгаа. Арми тариачны арми хэвээр байна. Хамтралжуулалтын дараа, нударганчуудыг устгасны дараа тариачид найдвар муутай болсон. Одоо ажилчдын дөрөвний гурав нударганчууд, тэдний гар хөл бологсодын хүүхдүүд.

Ганц Тухачевскийгээр хязгаарлаж, мэдээж, болохгүй нь. Армид буй аюул бүхий далд хүчийг бүрэн устгах хэрэгтэй. Гол толгойлогчид нь Тухачевский, Якир, Уборевич гурав.

Эд нар ч цуутай хүмүүс. Гэхдээ зөвхөн өнөөдөр цуутай. Харин маргааш хэн тэднийг санах

вэ? Октябрийн эргэлтийг хэрэг дээрээ Петроградын Зөвлөлийн Цэргийн Хувьсгалт хороо удирдсан. Троцкий, Дыбенко, Крыленко, Раскольников, Антонов-Овсеенко, Смилга, Бубнов, Зержинский, Подвойский, Свердлов, Милютин... энэ тэр. Одоо үүнийг хэн санаж байна? Свердлов, Зержинский хоёр нас барсан, заналт дайсан Троцкий хилийн чанадад байгаа, Смилга шоронд байгаа, бусдынх нь зам ч тийшээ...

Тухачевский, Якир, Уборевич гурвыг ч мартана, эсвэл урвагчид, тагнуул гэдгээр л санаж байх болно. Энэ гурав үзэл бодол нэгтнүүд, тэдний араас бусад нь зүүгдээд илрэнэ, командын бүрэлдэхүүн бараг бүгдээрээ зүүгдээд гараад ирнэ. Арми үүнийг даахдаа л нэг даана. 3-4 жилд удирдлагын шинэ боловсон хүчин бойжоод ирнэ. Бага дарга нар дунд, дунд дарга нар дээд офицер болцгооно. Үүнийг бүгд түүний ач гэж үзнэ, арми түүнийх болно.

Армийн учрыг нүд ирмэхийн зуурт олох хэрэгтэй. Одоохондоо Шмидт, Примаков, Путна гурав хангалттай. Дивиз командлагч Путна Тухачевскийн найз. 1923 оноос троцкийчуудтай нийлсэн. Хожим албан ёсоор тэднээс хөндийрсөн, гэхдээ сөрөг хүчний бүрэлдэхүүнд байсан, тэр нь гол зүйл. Тэр гурвыг Зиновьев, Каменев хоёрыг шүүх ажиллагаатай холбох хэрэгтэй, тэд нар тэр гурвын тухай мэдүүлэг өгөг. Ингэхэд, мэдээж, Тухачевскийн сэжиг төрнө, гэвч хууль бол хууль, шүүхэд өгсөн мэдүүлгийг шалгах албатай...

Харин одоохондоо тэдний сонор сэрэмжийг сулруулж, халамж анхаарал тавих хэрэгтэй.

Одоо армийг өнгөнөөс нь харвал цул бат нэгдэлтэй байна. Ворошилов армийг толгойлж байна. Орлогч нь Тухачевский. түүнийг нэгдүгээр орлогч болгох хэрэгтэй. Итгэл найдвар хүлээлгэж буйг мэдрэг, нөхөр Сталин юу ч гадарлахгүй байна гэж санаг.

Харин армийн цул нэгдлийг эвдэж, дотор нь давхрага үүсгэвэл зохино. Хаант засгийн арми шиг, дэлхийн аливаа армид байдаг шиг цэргийн цол бий болгох хэрэгтэй. Тэгснээр командын бүрэлдэхүүн цэргээсээ хөндийрнө, командын бүрэлдэхүүн өөрөө олон ангилалд хуваагдана. Цэргийн дарга нар эрх тушаалын сонирхолдоо хөтлөгдөн арми доторхи байр сууриа бодохоос биш, нам, улс орны байдлыг анхаарахаа болино.

Хамгийн гол хүмүүс-Ворошилов, Будённый, Блюхер, Егоров, Тухачевский нарт маршал цол, дараачийнханд нь генерал цол олгоно. Гэхдээ “генарал” цол эртдэх байх, хаант засгийн генералуудтай адилтгаад ойлгочихно. “Маршал” гэдэг үг бол францийн хувьсгалаас, Наполеоноос ч билүү, хаа нэгтэйгээс гаралтай, Хаант Орост тийм цол байгаагүй, фельдмаршал гэж байсан, маршал гэж байгаа-гүй. Генералын оронд арми командлагч, корпус командлагч, дивиз командлагч, бригад командлагч гээд түүнээс доош хаант засгийн армийн хурандаа, хошууч, ахмад энэ тэрийг авч болно. Бас дэслэгч ч гэж бий. Энэ талаар Егоров, Тухачевский хоёр бодог. Тэд хааны армид байхын энэ тухай сайн мэднэ.

Командын бүрэлдэхүүнд ангилал ангилалд нь таарсан цалин, өндөр цалин тогтоож, бас алба хаасан хугацааны нэмэгдэл цалин, өндөр тэтгэвэр, орон сууц, клуб гэх мэтийн тусгай хангамж бий болгоно. Тэр ч байтугай тусгай дүрэмт хувцастай болгоно. Ингэснээр армийг ард түмнээс улам хөндийрүүлнэ, ард түмэн цэргийн дарга нарт хэзээнээсээ дургүй.

ДЯАК-ын аппаратад холио солио хийх хугацаанд дээрх арга хэмжээ армийг төвийг сахисан

байдалд байлгана. Дараа нь ДЯАК-ын шинэ аппаратад түшиглэн цэргийн боловсон хүчнийг, Тухачевский, түүний бүлгийг, иргэний дайны баатрууд гэгчийг түргэн, шийдвэртэй цохих хэрэгтэй. Одоо энэ “баатрууд” хэнд ч хэрэггүй.

Энэхэн үеийн гол зорилт бол Кировын алуурчныг ашиглах явдал. Эхлээд троцкийчууд-зиновьевчуудыг ил шүүн таслах ажиллагаа явуулна, аль болох олон хүнийг татан оролцуулна. Тэгээд бүгдийг буудан ална.

Энэ ажиллагаа ил, далд бүх дайсныг устгах эхлэл болно, араас нь ил, хаалттай олон шүүн таслах ажиллагаа цувран үргэлжлэнэ, ийнхүү боловсон хүчний хувьсгалын эхлэл тавигдана.

Киров, Киров, Киров! Энэ гарзыг ард түмэн мартаж ёсгүй, энэ гарзыг ард түмэн санаж байх ёстой, тэгээд түүний өсийг байнга авч байх ёстой. Ард түмэн Кировыг хайрлаж байх ёстой, ард түмэн түүнийг ганц хором ч мартаж ёсгүй.

Кировын тухай ном, кино гаргах хэрэгтэй, хот тосгон, үйлдвэр завод, музей театруудыг түүний нэрэмжит болгох хэрэгтэй. Бүх юм ард түмэнд Кировыг санагдуулж байх ёстой, Киров үүрдийн шүтээн, үүрдийн зовлон, ард түмний аньдаггүй шарх байх ёстой. Энэ шархыг үргэлж сэдэрээж байх хэрэгтэй, энэ шарх толгой дараалан хөнөөж байвал зохих дайсны тухай ард түмэнд үүрдийн сануулга болох ёстой.

Кировтой Лениград хамт ажиллаж байсан бүх журмын нөхдийг нь устгажээ.

Ленинградын мужийн намын хорооны товчооны гишүүн бөгөөд БХК(б)Н-ын ТХ-ны орлогч болон жинхэнэ гишүүн Чудов, Кодацкий, Алексеев, Смородин, Позерн, Угаров, Струппе нарыг 1937-1939 онд буудан алжээ.

Түүнчлэн Ленинградын мужийн болон хотын намын хорооны намын хянан шалгах комиссын гишүүдийн олонхийг буудан алжээ.

Намын ХҮП их хуралд Ленинградын намын байгууллагаас сонгогдсон Киров тэргүүтэй 154 төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Сталин, Андреев, Шкирятов нар байсан бөгөөд 1939 онд намын ХҮП их хурлын төлөөлөгчөөр чухамхүү тэр гурав л үлджээ.

1935 оны намар, Сашагийн цөллөгт суугаа хоёрдахь намар ойртон айсуй. Үнээний байраа барьчихсан тул Саша дахиад ажилгүй болжээ. Тэртэй тэргүй ганцаардмал тэрбээр голын зайр гүйхийн хамт орчлонгоос бүр тасрана. Тосгон хүнгүй мэт болж, ноход хүртэл ичсэн гэлтэй. Саша хуучин сонин, сэтгүүлээ хэдий цээжилчихсэн ч дахин дахин уншина.

Зида 1935 оны зун амралтаараа охин руугаа яваад, есдүгээр сарын нэгэн гэхэд эргэж ирээгүй, сургуульд өөр нэг эмэгтэй багш ирүүлжээ. Бүрмөсөн явчихсан хэрэг. Сашатай хачин холбогдсон шигээ түүний амьдралаас хачин арилах нь энэ. Бүр өвөл болсон хойно Саша түүнээс нэг захиа авчээ. “Үүрд баяртай, Саша. Чиний надад хүртээсэн бүхэнд баярласан шүү. Чамд эрх чөлөө, аз жаргал хүсье. Хааяа намайг дурсаж байгаарай...”

Буцах хаяггүй захиа. Дугтуйн дээрх тамга нь гаргаж уншихын аргагүй аж. Ингээд арилжээ. Яагаад? Нөгөө өдрийн тэмдэглэлээс болов уу? мань хүн тэгэхэд чин сэтгэлээсээ гэмшиж уучлал гуйсан, Зида ч зөрж маргаагүй, бас гоморхоогүй, тэд эвлэх шиг болсон, гэхдээ л сорви үлдээсэн бололтой. Бас Варя. Саша түүнийг бодно, Зида мэдээгүй царайлж, хардаж барихгүй ч цаагуураа мэдрээд буй нь илт байдаг асан. Өөр ч юм байж мэднэ: Ангар руу хүн цөлөхөө болих сурагтай юм чинь Сашаг ч аваад явчихна, тэгэхээр ийм юмыг нүдээрээ үзэх нь дэмий гэж бодоод явчихсан, тэгээд эргэж ирээгүй юм болов уу. Тэгсэн нь ч зөв байх аа даа.

Саша Сталинд бичсэн захиагаа явуулахгүй л байв.

Сонинд найдвар төрүүлэхээр зүйл зөндөөн гарч байгаа нь мэдээж. Шинэ шинэ нэр, шинэ шинэ ардын баатрууд тодорсоор: уурхайн малтагч Стаханов, машинч Кривонос, зорогч Гудов, дархан Бусыгин, гуталчин Сметанин, нэхмэлчин хоёр Виноградова, тракторч хоёр эмэгтэй Ангелина, Кавардак. Эд нар бол үй олноороо хөдөлмөрийн гавьяа байгуулах эхлэлийг тавигчид. Москвагийн метроны эхний ээлж нээгдэж, олон үйлдвэр, завод ашиглалтад орж байна.

Дарлагдсан, аллага хядлагын дарамтад байгаа ард түмэн ийм их үйлсийг бүтээж чадна гэж үү? Үгүй ээ, ард түмэн дарлагдаагүй, аллага хядлагын дарамтад ороогүй, ард түмэн намын төлөө, Сталины төлөө байна, түүнд итгэж байна, түүнд үнэнч байна, Сталин ч ард түмэнтэйгээ хамт байна, металлургчид, хамтралчид цэргийн дарга нар гэхчилэн ард түмний төлөөлөгчидтэй байнга уулзаж байна.

Гэтэл, нөгөө талаас, Лениний журмын нөхдийн толгойг авсаар байхад Сашагийн, өөрийнх нь толгой юухан төдий байх билээ?

Дээхнээ “коммунист” гэдэг үг нэгэн үзэл бодолтны аугаа их гэр бүлд харьяалагдаж буйг илэрхийлдэг байсан бол одоо “цагаантан” гэдэг үгнээс аюултай болжээ. Цагаантанд ямар ч баг байхгүй, коммунист бол намын батлахаар баг хийж байгаа учраас түүнээс онц сэрэмжтэй байх хэрэгтэй. Сонинд ингэж л бичсэн байх юм.

Гэтэл мань дүнхүү толгой өөрийгөө мундаг улс төрч гэж дандаа боддог байж. Комсомолын дарга, нэг үе Свердловын коммунист их сургуульд, дараа нь Улаан эрдэмтдийн дээд

сургуульд орно, намын ажилтан болно гэж мөрөөдөж явсан. Гэвч эцсийн бүлэгт инженерийн мэргэжлийг сонгосон, улс оронд мэргэжилтэн хэрэгтэй, ирээдүйд аж ахуйн хүн болно, тэр бол бас л улс төрч гэсэн үг. Гэтэл мань хүн хэр улс төрч вэ? Ер нь улс төрч гэж юу юм бэ? Залуудаа улс төрийг энгийн, шув шулуухан, шудрага, үзэл сурталтай, элдэв явуулга, ов мэхгүй зүйл гэж бодож байсан. Гэтэл тэс өөр зүйл аж. Гэнэн дүнхүүдээ л ийшээ цөлөгдөж. Жинхэнэ овжин, уян хатан улс төрч байсан бол баярын ханын сонинд Сталины нэрийг дурдахгүй байж болохгүй, гавшгайчуулын зурганд егсөн тайлбар хийж болохгүй, нягтлан бодох бүртгэлийн багш марксизм-ленинизмээр халхавчилж байсан ч түүнтэй мэтгэлцэж болохгүй гэдгийг ухааралгүй яахав. Бас намын хурлаар орохдоо хүрсэн бол буруугаа хүлээж гэмших ёстой. Жинхэнэ улс төрч бол юу хэрэгтэй, юу хэрэггүй, юу болох, юу болохгүйг мэднэ.

Юрка Шарок ачигч болно гэж зүтгэлэлгүй дулаахан саруул цех дотор ажиллаж байхад мань хүн бороо цасанд торхтой будаг үүрч явсан. Юрка хуулийн анги төгсөөд одоо “тэнд” ажиллаж буй. Ээж нь захиандаа “тэнд” гэж бичсэнийг Саша дор нь ойлгосон билээ. Юра Шарок үнэн чанартаа бол эсэргүү, зөвлөлтийн эсрэг үзэлтэн, гэтэл тэр ДЯАК-т, мань хүн цөллөгт. Юра-овжин хулхи, мань хүн-борог эр Тэрээр түүх мэддэг, түүхийн хичээлд дуртай хэрнээ жинхэнэ сонирхлоо эс харгалзан, нийгмийн ухаан, түүхийн ангид оролгүй техникийн сургуульд оржээ. Түүхч хүн социалист байгуулалтад идэвхтэй оролцож чадах уу? түүний олсон, өөрийг нь алдаршуулсан хуучны нэг баримт домна зуухны сууринд барилгачны өрсөн нэг туйпууны дэргэд юухан байх билээ? Баримт бол өнгөрсөн үе, домна зуух бол ирээдүй. Саша материаллаг баялагийг хүн төрөлхтний хувьд, түүний дотор Орост шийдвэрлэх ач холбогдолтой гэж угаасаа үздэг учраас ингэж л бодно. Одоо Оросыг хоцрогдсон орноос тэргүүний орон, хөдөө аж ахуйн орноос аж үйлдвэрийн орон, өрнөн буй дэлхийн хувьсгалын түшиг тулгуур болох пролетарийн хүчирхэг гүрэн болгоход чухамхүү материаллаг баялаг л чухал. Архивын олдвор энд ямар пад байна?

Гэхдээ оюун санааны баялаггүйгээр хүн төрөлхтөн байж чадахгүй, гэхдээ тэр нь ард түмнийг хүмүүжүүлэхэд л зориулагдах ёстой. Саша түүхээс гадна утга зохиолд бас дуртай, оросоор төдийгүй францаар ном зохиол уншина, шүлэг амархан тогтооно, багадаа уйлж яваагүй хэрнээ ганц тансаг мөр шүлэгнээс болж мэлмэрүүлж өгнө.

Тэдний хөрш Михаил Юрьевич,

-Саша та яагаад юм бичдэггүй юм бэ? гэж асуух нь бий.

-Яагаад би бичих ёстой билээ?

-Бичдэг хүн санаагаа цэгцтэй сайхан илэрхийлж сурдаг юм. Бичиж чадна гэдэг бол сэхээтэн хүний анхны шинж, дээр үед сонгомол сургуульд зохиолч бэлтгэхгүй ч бичиж сургадаг байсан юм. Хааны Тосгоны лицейг сана л даа. Тэнд лицейн бичмэл сэтгүүл, утга зохиолын дугуйлан энэ тэр байгаагүй бол бид Пушкинтэй байх байсан эсэхэд би эргэлздэг шүү. Та том алдаа хийж байх шиг надад санагдах юм.

Саша Михаил Юрьевичийг байн байн санана. Мөн ч олон сайхан номоо уншуулсан даа. Баригдаад явахад нь салах ёс ёслох гэж хонгилд гарч ирээд мөнгө өгөх гэж байсан... Үзэл

бодол, итгэл үнэмшлээсээ ухардаггүй үнэнч шудрага, ёстой сайхан хүн. Хааны Тосгон. Лицей. Цөллөгийн энэхүү бөглүү Ангарт мөн ч сонин сонсогдож байх чинь вэ! Саша жуумалзав.

Тэрээр энд өдрийн тэмдэглэл хөтлөх битгий хэл, ямар нэг зүйл тэмдэглэхгүй. Ээжийнхээ, эцгийнхээ, Маркийн, хоёр нагац эгчийнхээ хаягийг цээжээр мэднэ, энэ бол хангалттай. мань хүнд тэмдэглэлийн дэвтэр ч байхгүй. Гэнэтхэн нэгжээд эхлэвэл, дэвтэрт байгаа нэрсийг шалгаана, тэнд нэр нь байсан төдийгөөс хүнийг хөнөөлгөж ч мэднэ.

Гагцхүү энэ махны тээрэмд л тээрэмдүүлчихгүй юмсан. Хугацаа дуусангуут л суллаж тавиасай. Өөрийг нь буруутгах юм байхгүй шүү дээ...

Гэвч буруутгах юмгүйгээр хугацаа сунгачихыг хэн байг гэхэв. Давж заалдах ч эрх байхгүй! Гэтэл гэнэт аз дайрвал яана! Суллагч хвал яахав?!

Суллаж гэмээ нь баахан им тамга тавина, мэдээж. Паспортанд тэмдэглэл хийнэ, хорь, гучин хотод суух эрх хасагдана. Тэгээд ажилд орох болвол биеийн байцаал заавал бөглөнө, ял эдлэж явснаа нуултай нь биш, тэгээд л авах уу, байх уу гэдэг асуулт гарна.

Биеийн байцаал бөглөдөггүй л нэг юм олох хэрэгтэй болно. Юу байж болох вэ? Чөлөөт мэргэжил. Ямар?.. мань хүн зурж чадахгүй, дуулах хоолой байхгүй, жүжигчин болох гэж хэзээ ч оролдож үзээгүй, нэмэрт нь театрт ажилд ороход биеийн байцаал бөглөнө. Федягаар баян хуур заалгаад сурчихгүй тусгүй юм болж. Сурчихсан бол нийтийн бүжгийн талбай, хурим энэ тэр дээр тоглоод юмхан олоод байхгүй юу. Федя мөд явчих юм чинь одоо нэгэнт оройтжээ.

Тэглээ ч гэсэн чөлөөт мэргэжил л хэрэгтэй. Бас далд нэр. Энэ гол зүйл! “Нөгөөдүүлийн бүхнийг үзэгч нүд, бүхнийг сонсогч чихнээс” далд нэрний ард л мань хүн нуугдчих юм байна. Гэтэл далд нэр зөвхөн зохиолч, яруу найрагчдад л байдаг. Тэгэхээр авьяас хэрэгтэй, өөрт нь авьяас байх биш.

Тэдний сургуульд утга зохиолын дугуйлан байсан ч Саша түүнд явж байгаагүй. Харин түүхийн дугуйланд явдаг, тэр дугуйланг Алексей Иванович Стражев гэж сайхан ярьдаг, ухаантай түүхийн багш удирддаг байсан. Тэдний дугуйлан тодорхой сэдвээр хичээллэдэг тул Саша Францын их хувьсгалын түүхийг сонгон авч тун махруу хичээллэсэн, бичсэн ажлыг нь багш нь магтаж байсан удаатай.

Гэвч Саша сонирхлоо орхиж, Тээврийн сургуульд орсон билээ. Гэхдээ гарт тааралдсан түүхийн чиглэлийн юмыг хуу уншдаг, тэр ч байтугай ном худалдаж авах боломж гарвал Францын их хувьсгалын тухай ном цуглуулдаг болжээ.

Тэр нь одоо хэрэг болж мэдэх нь! Бүр өвөл ээждээ захиж байж номоо авсан нь яамай... Одоо ширээн дээр нь байж байна. Ашиглавал, чухамдаа, ширгэшгүй сурвалж. Түүхийн нийтлэлийг, мэдээж, далд нэрээр хэвлэхгүй, гэхдээ уран сайхнаар боловсруулаад өгүүллэг, найруулал болгочихвол өөр хэрэг. Робеспьер, Сен-Жюст, Дантон нарын тухай, ХҮИ Людовик, Мария Антуанетта хоёрыг цаазласан тухай, Бастилийг эзлэсэн тухай, “Марсельеза” зохиосон Руже

де Лилегийн тухай энэ тэр гээд мөн ч олон нэр, мөн ч олон үйл явдал байна даа.

Саша анхныхаа өгүүллэгийг Сен-Жюстийн тухай бичиж эхлэв. Сайн, муу болж буйн алиныг ч эс мэдэвч бичээд байлаа. Дахиж баригдаад, энэ цааснууд нь нэгжлэгээр илэрвэл, “Хүүхэд, залуучуудад зориулан өгүүллэг найруулал бичдэг юм” гэж хэлнэ. Цаадуул нь, мөн “зохиолч” олдов оо гэж тохуурхах биз, гэхдээ хэн ч өгүүллэг бичих эрхтэй юм чинь гэмт хэргийн бүрэлдэхүүн олохгүй. Зөвлөлтийн эсрэг бичлэг биш, харин ч Маркс, Энгельс, Ленин нарын их өндөр үнэлж байсан хувьсгалын тухай өгүүллэг. Владимир Ильич Ленин түүнийг аугаа их хувьсгал гэж нэрлэсэн шүү дээ.

Гол нь аль болохоор ахиухан бичих хэрэгтэй.

Саша зогсоо чөлөөгүй бичиж гарчээ. Хуудас болгоноо, бүлэг болгоноо хэд дахин засч бичнэ, дараа нь бүтэн өгүүллэгээ засна. Яг эцэслэсэн хувилбараа нэгийг өөртөө, нөгөөг ээждээ зориулж хоёр хувь (хортой цаас байхгүй учир) хуулж бичнэ. Юу эс тохиолдож болохыг тэр гэх вэ, үгүйдээн аль нэг хувь нь үлдэнэ биз. Тэрээр өвлийн анхны шуудангаар ээждээ явуулах гэж яарч байгаа билээ.

Саша Францын их хувьсгалын тухай анхныхаа өгүүллэгүүдийг ээждээ 1936 оны өвөл сая нэг явуулав.

“Чөлөө завгай болохоор ийнхүү үзэг цаасаар зугаацаж байна. Гагцхүү хэнд ч битгий үзүүлээрэй”.

Харин одоо хэр Саша урьдын адил уйтгартай, ганцаардмал хэвээрээ. Лидия Григорьевна дээр очихоор маргахаас өөр юмгүй тул залхаж гүйцжээ.

Федя дээр л очих нь элбэг. түүний умгар мухлаг өвөрмөц тохьтой, бас аж ахуйн барааны өвөрмөц үнэртэй. Федя ажилдаа их махруу. Тэр нь ч цаанаа нэг өвөрмөц. мань хүн Сашаг уриалгахан угтана. түүнд бараа ирэхээ больсон учраас цаг зав ч хангалттай. Чарганы зам гармагц Мозговад шинэ худалдагч ирнэ, Федя 1936 оны 1 дүгээр сарын 1-ээс Красноярскт дамжаанд орохоор болсон, хоёр жилийн дараа районы эд хэрэглэгчдийн холбооны дарга болно, хэрэв даргынхаа нүдэнд зөв харагдвал Красноярскт, хязгаарын эд хэрэглэгчдийн холбоонд үлдээнэ.

-Одоо тойргуудыг устгачихсан, чи мэдэх үү? Муж гэх болсон, бас хязгаар. Муж гэдэг нь дан оросууд суудаг нутаг, хязгаар гэдэг нь оросоос гадна бусад ү н д э с т э н - тунгусууд суудаг нутаг. Одоо бол эвенк, хакас, долган, ненец гэхчилэн хэлэх болж. Тийм учраас хязгаар. Бүх юм бүтнэ! Энд би юу хийхэв? Ахих дөхөх зам алга! Худалдагчаас район руу дэвшинэ гэж байхгүй, сургууль ном хийсэн хүмүүсийг дээрээс ирүүлчихнэ. Мозговад хэн байна, хэн ч алга, наймаа хийх хүн ч алга, би энд юу хийх вэ? Үүрэглээд суух уу... Эцэг эх хоёр удахгүй үхнэ, Мария хүнтэй суучихсан... Лариска? Тэр салмал хүүхнээр би яахав? Красноярскт очоод хотын, боловсролтой хүүхэн олж авна.

Федя, одоо цөллөгт буй, дараа нь юу болохоо мэдэхгүй хүн урд нь сууж байгаад өчүүхэн ч төдий санаа зовохгүй, өөрийнхөө гялалз-сан ирээдүйг ийнхүү дүрсэлнэ. Тэрээр орчлонгийн

явдал шудрага зо-хион байгуулалттай гэдэгт бат итгэнэ. Нэг хэсэг нь дээшээ дэвшинэ, нөгөө нь доошоо бууна, гуравдахь нь байрандаа үлдэнэ, хүн болгон өөртөө заяагдсанаар сэтгэл ханах ёстой. Хэрэв хүн болгон дарга болох гэж зүтгэх юм бол үнэн замбараагүй юм болно. Дэг журам гэдэг бол дарга нар хүн болгоныг байр байранд нь тавина гэсэн үг.

Федяд гайхмаар өөр бас нэг юм бий. Саша урьд хөдөөгийн комсомолын идэвхтэнүүдтэй уулзаж явсан, тэд шал өөр хүмүүс. Хувийн ашиг, дэвших дээшлэхээ хэн нь ч бодохгүй, нийтийн үйл хэрэгт үнэнч хүмүүс. Тэдний хувьд намын ашиг сонирхол л гол бөгөөд цорын ганц ашиг сонирхол. Федягийн хувьд ганц ашиг сонирхол нь түүний хувийн ашиг сонирхол, чин санаанаасаа үүнийг мэдээжийн зүйл гэж үзнэ. Хаанахын ёс вэ? Хөгжөөгүй, боловсроогүйнх үү, эсвэл шинэ маягийн идэвхтний шинж тэмдэг үү? Саша иймэрхүү шинжийг Лозгачев, Шарок хоёроос тухайн үедээ олж харж байсан, тэгэхэд ганц нэгхэн хүний л янз шиг санагдаад өнгөрсөн бол одоо тэр нь олон түмнийг хамарч, нийгмийн шинэ төрхтөн бүрдэж байгаа ажээ.

Гэвч Сашад нийлэх өөр нэг ч хүн байхгүйн учир Федятай байгаагаар нь ханилахаас өөр яахав.

Тэр хоёр голдуу агуулахад нийлж сууцгана. Юм ч балгана, Федя заримдаа гармонио авч, хөгжимдөн дуулна:

Мөрөн голын хөвөөнөө

Мөн чиг сайхан газар

Загасчид аж төрдөг

Зантай гоё байшин байж.

Тэнд загасчин эр эхнэртэйгээ

Загасчилж аж төрдөг байж.

Тэднийх цагаан хэл ам хүрэм

Гурван сайхан хүүтэй юм байж.

Нэг нь тариачин бүсгүйд хайртай болж.

Нөгөө нь намын гишүүнд дурлаж.

Гуравдахь нь анчны залуухан эхнэр,

Гуалиг сэвгэрт сэтгэл алдаж.

Ингэж дуулаад Федя жогтой царайлан Саша руу нүд ирмэнэ...

Хэрэмний гөрөө хийхээр анчин эр

Хөвчийн ой руу нэгэнтээ мордож.

Төлөгчин удгантай таарч

Төөрөг юүгээн үзүүлж.

Хамаг хөзрөө сайхь эм дэлгэж.

Хариу тайлахаас эмээн сандарч:

Эхнэр нь энгэр буруулсныг илтгэх

Дөрвөлжингийн ноён тэр байна

Эмийн булшийг ёрлох

Хөзрийн зургаа дэргэд нь байна.

Мэгдэж уймарсан анчин маань

Мэрэгч удганы гарыг цайлгаад

Тэр даруй мориндоо дөрөөлж

Гэрийн зүг жолоогоо эргүүлэв.

Гэртээ дөтлөн очвол

Гэргий нь үүднийхээ тэрүүхэнд

Загасчин хөвүүнд тэврүүлчихсэн

Залгих нь халаг үнсэлж байж.

Анчин үүрсэн винтовоо мулталж

Авгайсаг загасчинг онилж буудлаа.

Хөвүүн газар үхэдхийн унаж

Хүрэн улаан цусандаа хутгалдлаа.

Нэг удаа Федя Сашаг шөнийн загасанд дагуулж явжээ.

Завиныхаа хошуун дээр хоовонд гал түлж гэрдэнэ. Федя эхлээд загас сэрээдэхийг үзүүлж, том жижиг олон загас агналаа. Нэг том тул авлаа.

Дараа нь сэрээгээ Сашад өгч,

-За байраа эзэл! гэв.

Завь чимээгүй зугуухан урагшилж, усанд туссан гэрэлд Саша голын ёроолыг тод харж явлаа. Гэвч загас алга... Тэгтэл гэнэтхэн гэрлийн туяанд гулдайсан тул ороод ирлээ. Загас юу тохиосныг үл ойлгон самгардсан мэт байрандаа зоогдчихоод, зөвхөн сэлүүр нь үл мэдэг хөдлөн байна. Саша биеэ хураатал толгойд нь “Энэ тулыг намнаж чадвал захиагаа явуулна” гэх бодол зурсхийлээ. Тэр даруй сэрээгээ хүчтэй дүрэв. Сэрээний шүд тулны нуруу руу хурхийгээд орчих нь тэр. Ус булингартан, сэрээний иш гарт нь чичирхийлэхэд Саша биеийн хүчээр дарж загасаа ёроол руу шахав.

-Гүйцлээ, гаргаад ир! гэж Федя зөөлхөн хэлэв.

Саша сэрээгээ олин гаргахад сүлбүүлсэн аврага тул чичигнэн байна. Завины ёроол руу олон загасны дээрээс хаяад сэрээгээ сугалж авлаа.

-Чи яггүй загасчлах төлөвтэй гэж Федя хэлэв.

Саша мэрэг совинд үл итгэнэ. Захиагаа явуулахаар шийдсэн нь тул алахдаа мэрэг тавьсных биш. Өнөө маргаашгүй голын зайр гүйнэ, маргаашийн шуудан сүүлчийнх, түүгээр захиагаа илгээхгүй бол гол хадаалж чарганы зам гартал хүлээх хэрэг болно. Явуулчихвал захиа нь мөд Москвад очно. Тэгтэл! Тэгтэл яаж ийгээд Сталины ширээн дээр оччихвол яана!

Саша захиагаа нямбай гэгч нь хуулж бичээд, дугтуйлж “Москва, Кремль, нөхөр Сталинд” гэж хаяглаад марк наалаа. Маргааш нь шуудангийн завь ирэв. Шуудан хүргэгч дугтуйн дээр “баталгаатай” гэж буйг хараад “Баримт нь өвөл шүү” (баримтыг Кежмад бичдэг юм) хэмээн сануулснаа шуудангийн богц руу захидлыг шидчихээд сэлүүрээ авлаа.

Ингээд Сашагийн захидал Ангар уруудан Москва руу, Кремль рүү, нөхөр Сталин руу хөвж өгөх нь тэр.

1935 оны арван хоёрдугаар сард өвлийн анхны шуудан ирлээ. Яг тэр өдөр нь Лидия Григорьевна Звягурог Красноярск руу явуулжээ. Саша түүний олсоор боосон хоёр хуучин чемоданыг чарган дээр тавиад, буцаж ирж, зузаан саарал алчуураар ороосон Тарасикийг тэврэн өргөв.

-“Тэргүүндээ гурвалжин бүрх духдуулж, тэлээ энгэрт аяны саарал нөмрөг агсчээ” гэж Саша тоглоом хийв.

Тарасик нэг юм аяархан шивэгнэв.

-Юу гэнэв, Тарасик?

-Үхсэн хүн авснаасаа босч ирдэггүй. Би аав, ээж хоёрыг үхэхийг үзсэн. Бас завиар ч явахгүй. Чи худлаа ярьсан.

Тэгж хэлээд Саша руу зэмлэнгүй харлаа.

Лариска үүднийхээ довжоон дээр орь дуу тавин уйлна.

-Лариска, болиоч, та Тарасыг айлгаж байна шүү гэж Лидия Григорьевна ширүүлэв.

Лариска орь дуугаа татсан ч, хамар нь шуухитнан, алчуурныхаа захаар нулимсаа арчин мэгшинэ.

Лидия Григорьевна Сашад гараа өгөв.

-Саша баяртай, миний төлөө хийсэн бүхэнд чинь баярлалаа.

-Би танд юу хийсэн билээ? гээд Саша инээв.

-Хийсэн. Баярлалаа.

-Очсон шинэ газраасаа захиа бичиж болно биз дээ?

-Юу л бол. Жүжиг дөнгөж эхлэж байна.

Улаач жолоогоо дугтрав. Чарга хөдлөж, холдон холдсоор мод руу далд орлоо. Лидия Григорьевна нэг ч удаа эргэж харсангүй. Тарасик бас.

Саша ингээд Мозговад ганцаараа үлдлээ.

Хожим, наймдугаар сард, “Нэгдсэн төв” гэгчийг шүүн таслах ажиллагааны үеэр шоронд нэг энт сууж байсан хүмүүсийг шүүж эхлэхэд, Лидия Григорьевнаг чухамхүү тэр шүүх ажиллагаатай холбогдуулан Москва руу явуулсан байх гэж Саша боджээ. Гэвч шүүх хурлын тухай тайланд түүний нэр огт үзэгдээгүй, Тарасик тэр хоёр тэгээд юу болсныг Саша хэзээ ч

олж мэдэж чадаагүй билээ.

Тэрээр Лидия Григорьевнаг үдэж өгөөд гэртээ ирж шуудангаа янзлахаар суув. Москвагаас аль зун, намраар явуулсан захидал, сонин гээд зөндөөн шуудан иржээ.

Ээж нь дүнгийн дэвтэр, жолоочийн үнэмлэхийг нь олсон, Сашаг иртэл сайн хадгална гэж бичсэн байв. Захьсан номнуудыг нь явуулсан гэнэ. Сайхан захиа. Үнэмлэх энэ тэрээ олохыг захивал ээж нь тайвширна гэж Саша тооцсон нь зөв болжээ.

Хэрэв түүнийг суллахгүй бол тэр цааснууд өөрт нь хэрэг болох-гүй нь мэдээж. Тэглээ ч гэсэн албан ёсны биет зүйл, ирээдүйтэй холбож болзошгүй нэг учиг. Үгүй ээ, хориход орчихвол хэрэг болно, мод бэлтгэл рүү хөөгөөд байхгүй, мэргэжлийн ажил өгөх талтай. Сталинд явуулсан захидлын хариу алга. Ер нь ч хоёр, гуравдугаар сараас наашгүй гэж Саша баримжаалж байгаа билээ.

Тэрээр сахлаа дахиад ургуулжээ. Энд хэний төлөө, юуны учир сахлаа хусах вэ дээ. Жаврыг эс харгалзан цанаар зугаална, олз омог эс олдовч ан хийх гэж оролдоно.

Нэг удаа улаан армийнхны дуулгатай хэдэн цаначидтай таарчээ. Өөрөө ганцаараа, цаадуул нь тавуулаа учир зам тавьж өгч зогслоо.

Нөгөөдүүл нь ч бас зогсчээ.

-Сайн байна уу, ламтан гуай?

Сахалтай болохоор нь ламтан гуай гэсэн байх.

-Сайн, сайн байцгаана уу. Саша энэ нутагт улаан армийнхны барааг ч хараагүй учир тэднийг шохоорхон ажиглав. Хөмсөг, сормуус нь цантаж, хацар нь улаа бутарсан биерхүү сайхан залуучууд. Цөмөөрөө ижилхэн ноосон цамц, хөвөнтэй өмд, үстэй захтай хүрэм, эсгий гуталтай. Дор бүрдээ жижигхэн чаргатай.

-Энэ ямар тосгон бэ? гэж эхний цэрэг асуув.

-Мозгова.

-Яг Мозгова байна. Кежма хүртэл хэд вэ?

-Арван хоёр километр.

-Зүйтэй, яг тийм байх ёстой.

-Та нар хаанаас явж байна гэж Саша асуув.

-Нижнеангарскаас. Байгал-Баренцовын тэнгисийн цанын аялал гэж дуулсан уу?

-Үгүй.

-Ламтан гуай, сонин уншиж байх хэрэгтэй, та бичиг үсэг мэдэх үү?

-Бичиг үсэгтэй гээд Саша инээмсэглэв.

-Тэгвэл уншиж бай.

-Уншина аа. Та нарын чарганд юу байгаа юм бэ?

-Уутан хөнжил, аялалын эд хогшил. Аялалын зам дөрвөн мянган километр.

-Мөн их ээ. Гараад удаж байна уу? хэмээн Саша толгой сэгсрэв.

-Сар явж байна, Байгалийн нуруу хөөдчихлөө. Байгалийн нурууг мэдэх үү?

-Мэднэ.

Цаначин шовшров.

-Ёстой хатуухан даваа! Нисмээр цавчим мөргүү, явахын аргагүй битүү бут, хийсгэм хуй салхи, чөмөг царцам жавар...

-Та нар ч хэцүүхэн юм үзжээ.

-Мөн үгээ олов оо! Гол нь хугацаа их алдчихлаа. Кежмад биднийг одоо тавдах хоногоо хүлээж байгаа.

-Кежмаас хаашаа явах вэ?

-Тэндээс Подкаменная Тунгуска гол руу явна... За, ламтан гуай, үг олдох нь гээд цаначин таягаа өргөж нөхөд рүүгээ заав:

-Ламтан гуай, тогтоож аваарай! Түүхт агшин. Умрын их марафоныг өөрийнхөө нүдээр харлаа шүү. Марафон гэж мэдэх үү?

-Мэднэ гээд Саша дахин инээмсэглэв.

-Ламтан гуай, та ч боловсролтой хүн бололтой. Анчин юм уу?

-Анчин. Би яаж тогтоох болж байна? Таны алдар хэн бэ?

Ахлагч бээлийгээр цээжээ савав.

-Би Егоров Евгений хэмээснээ нөхдийгөө зааж, -Попов Иван, Куликов Андрей, Бражников Константин, Шевченко Александр гэв. Тогтоох уу?

-Тогтооно. Гарцаагүй.

-За болоо. Хүүхэддээ, бас ач гучдаа ярьж өгөхгүй юу. Умрын их марафоны баатруудыг харсан

Энэ тэр гээд. За, баяртай, ламтан гуай!

Тэгээд туршлагатай цаначны зугуухан итгэлтэй алхаагаар Кежмаг чиглэн гулсуулж одоцгоох нь тэр.

Хожим зун болсон хойно Саша, тавдугаар сарын сонины дугаарт, таван эрэлхэг зоригт цаначид 151 хоног аялаад 1936 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдрийн 18 цагт Мурманскт барианд орлоо гэж бичсэн байхыг олж үзжээ.

Харин цаначидтай уулзсаны дараанаас Саша Сталинд явуулсан захидлынхаа хариуг шимтэн хүлээх болжээ.

Гэтэл хоёр, гурав, дөрөвдүгээр сар өнгөрсөн боловч хариу байдаггүй.

Ангарын цөн түрж гүйцээд ус нь ч савандаа орж, хяруу цохьсон хар мод шилмүүлэх шинжээ оллоо...

Саша уул нь хаварт дуртай, өөрөө ч сэргэж, орчлон ч баяр баясал, горьдлого найдвараар дүүрээд ирэх шиг болдог билээ. Харин энд, Ангарын хөвөөнд бол хавар түүний хувьд ганцаардал, уйтгар гуниг, муу совин гэлтэй. Зургадугаар сар хүртэл шуудан дахиад тасрана. Ном, сонин, захидлуудаа тоогүй олон дахин уншсан, үг солих хүн ч байхгүй. Федя хүртэл яваад өгсөн. Сашагийн хугацаа нэгдүгээр сарын 19-нд дуусах ёстой, тэр болтол хагас жил гаруйхан үлдээд байна. Хугацаа сунгадаг болов уу? Хорих руу шилжүүлчих болов уу? Захиа нь Сталинд хүрээгүй, хүрнэ гэж найдсан нь ч тэнэг явдал, өөрийнх нь хэрэгт хавсаргаад нэг тийш нь хийчихээ биз... Амьдрал ингээд дууслаа! Энэ нутагт суурьшихийг зөвшөөрлөө ч гэсэн мань хүн юу хийх юм бэ? Лукешкагийн ярьдгаар ангарчлагдах хэрэг үү? Хар модны давирхайг бохь болгон ам хамхихгүй шалир шалир зажилж байдаг тэр бичиг үсэг ч үгүй басгантай суух уу? Тэр давирхайг шүдэнд сайн, бас бамнаас сэргийлдэг гэлцэх. Саша там-хиа багасгах санаатай түүнийг зажлах гэж үзсэн боловч давирхай ханхалж, заримдаа огимоор хачин амтагдаж шүдэнд нь наалдаад болж өгөөгүй. Соловейчик эндээс оргосон нь зөв байж дээ. Амьд гарсан бол одоо эрх чөлөөтэй яваа, баригдсан бол шоронд л сууж байгаа. Тэгээд юу гэж? Бусад нь оргоогүй хэрнээ сууж л байна. түүнд эрх чөлөөтэй болох бага ч гэсэн горьдлого байж шүү дээ.

Ахлах төлөөлөгчөөс Молчанов дээр дуудагдсан нь ганц Шарок болж таарав. Хэлтэс, тасгийн дарга нар, тэдний орлогчид, туслахууд нийлсэн гучаад хүн, дөчөөд ч байж магадгүй, ширээ тойрон суудлаа эзэлцгээж байна. Шарок тэднийг тоолоогүй, мөрдэсээр нь харахад мань хүн л ганц хөндөлтэй, бусад нь хоёр, гуравтай, ганц нэг хүн бүр комиссарын таван хошуутай байжээ.

Молчанов хүрэн хар үстэй, хээгүйдүү эвлэгхэн царайтай, хүдэр чийрэг биетэй, дунд зэргийн чацтай эр. Харахад хөрзгөрдүү ч хошигнох, егөхөөс буцахгүй.

Харин өнөөдөр тун албархуу харагдана. Тэрээр троцкийчууд-зиновьевчуудын хуйвалдаан илэрснийг ил сэтгэлийн хөдөлгөөнгүй мэдэгдэв. Тэр хуйвалдааныг гадаадаас Троцкий өөрөө чиглүүлж, дотоодод Зиновьев, Каменев, Бакаев, Евдокимов болон бусад зиновьевчууд, түүнчлэн Смирнов, Мрачковский нарын зартай троцкийчууд толгойлж байгаа ажээ. Смирнов, Мрачковский хоёр шоронд удаж байгаа нь үнэн, гэхдээ тэндээс ажиллаад буй гэнэ.

Цааш нь түүний хэлснээр бол зиновьевчууд, троцкийчууд “Нэгдсэн төв”-д орцгоож Сталин, Улс төрийн Товчооны бусад гишүүнийг алаад засгийн эрхийг авах зорилго бүхий алан хядагчдын бүлгүүдийг орон даяар байгуулжээ. Кировыг тэд нэгэнт алчихаад байгаа.

Нэгдүгээр сарын шүүн таслах ажиллагаан дээр Зиновьев, Каменев хоёр Кировын аллагад ёс суртахууны хариуцлагатайгаа хүлээсэн нь эрүүгийн хариуцлагаас мултрах, “Нэгдсэн төв”-өө нуух, өөрсдийн алан хядах байгууллага, алан хядагчдынхаа бүлгүүдийг нуух, цаг хожих гэсэн заль мэх төдий байжээ.

Молчанов үгээ таслан түр азнаснаа их намжиртай үргэлжлүүлэв.

-Нөхөр Сталин, Улс төрийн Товчоо энэ хэргийг нотлогдсон гэж үзэж байгаа. Тэр тухайд ямар ч эргэлзээ байхгүй, байх ч ёсгүй. Бидний хувьд бол тэр яллагдагчдаар хэргийг нь хүлээлгэх л ганц зорилт байна. Нөхөр Сталин, ТХ-ны нарийн бичгийн дарга Ежов нар мөрдлөгийн ажлыг б и е ч л э н хяналтдаа авч байгааг анхаараарай. Ойлгомжтой юу?!

Тэрээр дахин түр азнаснаа эрсхэн ингэж хэлэв:

-Бидэнд онцгой хариуцлагатай даалгавар оногдлоо. Тавигдсан зорилтыг бид бүрэн дүүрэн биелүүлэх үүрэгтэй. Намын Төв Хороо, нөхөр Сталины биечлэн үзүүлсэн өндөр итгэлийн хариуд чекистүүд намдаа, намынхаа эрхэм дээд ашиг сонирхолд хязгааргүй үнэнч гэдгийг бид батлан харуулах ёстой. Асуулт байна уу? хэн ч дуугарсангүй.

-За тэгвэл сонсоцгоож бай... гэж Молчанов дахин ам нээгээд, -Нөхөр Ягодын тушаал ёсоор та нар бүгд хуучин хэргээ өөр мөрдөн байцаагчдад шилжүүлээд миний мэдэлд ирцгээнэ гэв.

Тэрээр эцэст нь мөрдөн байцаагчдыг хэсэглэсэн хуваарийг уншиж сонсоход Шарок нэг бүлгийн бүрэлдэхүүнд өөрийнх нь нэр орсныг сонслоо.

Молчановын хийлгэсэн зөвлөлгөөн дээр хэн ч асуулт тавьсангүй. Гэхдээ асуух юм хүн болгоны толгойд орж ирснийг Шарок сайн ойлгож байгаа билээ.

Хуучин сөрөг хүчнийхэн хаа ч байлаа гэсэн тэднийг нэг бүрчлэн байнга ажиглаж байгаа нүсэр том тагнуулын албатай, бүхнийг хэрж торлосон мэдээлэгчдийн сүлжээтэй ДЯАК Зөвлөлтөөр нэг тарчихсан алан хядагчдын бүлэг, тийм өргөн хүрээтэй хуйвалдааны тухай мэдэхгүй байна гэж байх уу? Ийм юм тохиолдож болох уу? ДЯАК ийм байгууллагыг яагаад анзаарсангүй вэ? Тэгэх тусмаа хэдэн жил болсон байгууллагыг? Молчанов тэгж хэлсэн шүү дээ. Тэд нар, ДЯАК-ын ажилтнууд түүнийг олж хараагүй байх нь. Тэгвэл тэднийг бүгдийг нь шүүхэд өгвөл таармаар. Гэтэл ганц үгний зэм ч алга. Вутковскийн толгойлдог тэдний тасаг л троцкийцууд, зиновьевчууд, баруунтнуудыг хариуцдаг шүү дээ.

Хурал дээр Вутковский их дүнсгэр харагдсан. Молчановын ярьсан зүйлд бусдын адил, аягүй бол тэднээс ч илүү байх, цочирдож байгааг нь Шарок мэдэрчээ. Өөрийнх нь тасгийн шууд хариуцсан ажил юм чинь арга ч үгүй биз. Чухамдаа, тэдний ажилтнууд энэ хэргийг олж харсангүй шүү дээ.

Тэд нарт олж хараагүй юм байхгүйг Шарок ойлгож байгаа билээ. Ер нь цөмөөрөө ойлгож байгаа. Алан хядах ямар ч бүлэг байхгүй, өргөн хүрээтэй ямар ч хуйвалдаан байхгүй, байх ч ёсгүй. Энэ хуйвалдааныг Зиновьев, Каменев, Смирнов, Мрачковский нар болон Сталинтай зөрж байсан бусад зүтгэлтнийг буудан алахын тулд бий болгох ёстой.

Тэгэхээр Шарокийн зорилт бол яллагдагчдаас шаардлагатай мэдүүлгийг хэлүүлж авах явдал. Цаадуул нь тийм мэдүүлэг өгөхгүй. Ямар ч атугай Зиновьев, Каменев хоёр шүү дээ. Аргагүй томчуул... Уул нь тэднийг үнэхээр буудан тонилговол тун зүгээр сэн. Нэмэрт нь, бас еврейчүүд. Харин троцкийчууд, Смирнов, Мрачковский, Пятаков, Муралов энэ тэр гээд ихэнх нь еврей биш, гэхдээ гэжүүд, чанга ардууд, тэднээс мэдүүлэг салгана гэвэл гонж. Энэ бүхэн юугаар дуусдаг бол? Кировын хэрэг Запорожецийн хувьд яаж дууслаа даа?

Вутковский хэрхэн ажиллах төлөвлөгөөг тасгийнхаа ажилтан нарт танилцуулав. Түүгээр бол шорон, хорих, цөллөгнөөс хуучин сөрөг хүчний хэдэн зуун хүнийг Москвад авчирна. Тэдний дөнгөж аравны нэг хувь нь дээрх алан хядах байгууллага бий гэдгийг хүлээн зөвшөөрлөө гэхэд хорь гучин мэдүүлэгтэй болно. Гол хэрэгтнүүдийг нугалж авахад энэ хангалттай. Харин ингэж дэлбэлэхийн тулд “тэслүүр” хэрэгтэй. Үүнд зориулан гурван хүн товложээ. Валентин Ольберг, Исаак Рейнгольд, Ричард Пикель гурав.

Шарок Ольбергийг мэдэхгүй. Тэр Берлинд, хожим Турк, Чехос-ловакт сууж байгаад ЗСБНХУ-д ирснээсээ хойш Горький хотын сурганы дээд сургуульд ажиллаж байжээ.

Молчанов, Вутковский хоёр түүний ач холбогдлыг шууд үнэлжээ. Юу гэвэл, Ольберг хилийн чанадаас саяхан ирсэн, Троцкийн хүү Седовтой танил, тэгэхээр Троцкийн даалгавраар Сталиныг алах ажлыг зохион байгуулахаар Седов түүнийг ЗСБНХУ-д явуулсан гэдэг мэдүүлэгт гарын үсэг зурна. түүнээс гадна Горькийн сурганы сургуульд “Лениний гэрээс” гэж оюутнууд гар дамжуулан уншдаг зүйл бий. Тэр оюутнууд л Сталиныг алах гэсэн бүлэг болж таарна.

Ольберг “зөөлхөн” яллагдагч мөн боловч Шарокт ноогдсонгүй, түүнийг гадаад хэлтсийнхэн мөрдөнө.

Зиновьевын тамгын газрын дарга асан Ричард Пикель Шарокт бас ноогдсонгүй. Пикель хэсэгхэн хугацаанд сөрөг хүчинтэй нийлж байгаад тэднээс бүрмөсөн салсан ч ДЯАК-т данстай байж. Шарок түүний хавгаст хэргийг үзжээ. Иргэний дайнд оролцсон. Хориод оны хоёрдугаар хагасаас улс төрөөс хөндийрч, утга зохиол оролдон театрт ажиллажээ. Хэрэгт хувийнх нь тодорхойлолт ч байна: хүнтэй нийцтэй, зөөлөн халирхай зантай, хөзөр сайн тоглоно. Бас хавгаст хэрэгт ороогүй ч мэдээлэгчдийн мэдээн дотор зарим зүйл байна: Пикель Гай, Шанин хоёртой хөзөр тоглодог аж. Тэр хоёр нэртэй чекистүүд, Гай нь тусгай хэлтсийн дарга, Шанин тээврийн хэлтсийнх. Пикель тэднийхний зуслангаар байсхийгээд очно, бас тэдний дэмээр гадаадад явна. Пикелийг өөрт нь өгөхгүй гэдгийг Шарок ойлгожээ. түүнийг үнэхээр ч Гайн хүмүүс байцаахаар болж.

Шарокийн орсон мөрдлөгийн хэсэгт сайхь гурвын хамгийн хэцүү нь болох Рейнгольд ноогджээ.

Рейнгольд сөрөг хүчинтэй нэгхэн зуур нийлж байгаад тэднээс салсан боловч Пикель шиг бас дансанд байжээ. Хөвөнгийн аж үйлдвэрийн ерөнхий газрын дарга байсан, цууд гарсан аж ахуйн зүтгэлтэн. Өнгөрсөн оны нэгдүгээр сард Кировын хэргээр түүний орлогч Файвиловичийг баривчилжээ. Тэр даруйд Рейнгольдийг ажлаас нь халж, намаас хөөжээ. 1935 оны нэгдүгээр сарын 11-ний “Правда”-д “Рейнгольд сөрөг хүчний увайгүй шаар Файвиловичтэй найман жилийн турш хамгийн дотно харилцаатай, хамгийн нягт сүлбээтэй байсан юм” гэж бичсэн байв.

Тэгэхэд тун хол шагайж байсан юмсанж. Рейнгольд Соколь-никовын хамаатан, тэднийхээ зуслан дээр Каменевтай уулздаг байж. Чухамхүү энэ учраас түүнийг “тэслүүр” болгохоор сонгоо биз. Тагнуулын мэдээнээс үзвэл эзэрхий, дураараа айхтар хүн. Товчдоо амаргүй хулхи.

Шарокийн энэ таамаглалыг тасгийн дарга Вутковский ч бас нотложээ. Хянуур, амарлингуй польш. Газартаа төдийгүй яамандаа хамгийн ухаантай хүний нэг. Тэрээр Рейнгольдын хавгаст хэргийг үзээд албан ёсны мэдүүлэг өгөхгүй, ер нь юм ярихгүй хүн гэж дүгнэжээ.

-За яахав, та түүний сахиус болж таарах нь хэмээн Вутковский Шарокт үүрэг буулгав.

Энэ бол тодорхой удирдамж: Рейнгольд бууж өгөхгүй бол түүнийг Шарок “нугалахгүй”, өөр хүн “нугална” гэсэн үг. Шарок бол Рейнгольдын итгэлийг олж, цааш найдах хүн нь болоод, цаашаа бусад хүн “нугартал” нь байцаах хүртэл тийм дүрээрээ байна.

Шарокийн сэтгэлд энэ үүрэг их нийцжээ. “Нугалах” бол балиар ажил. Бусад нь л тийм ажил хийнэ биз.

Шарок анхны байцаалт явуулдаг тогтсон аргын дагуу Рейнгольд руу бүрхүүлтэй чийдэнг өлийлгөж тусгаснаа доош нь дараад, суу хэмээн хайнга тушааж, түүний хэргийг судалж буй дүр гарган баахан цаас үзэж эхлэв.

Цаасаа үзэж дуусаад хажуу тийш нь тавьснаа, мэдүүлгийн маягтаа авч биеийн байцаалын асуултнаас хэнэггүй тайван асууж эхлэв.

Рейнгольд ч Шарокийн нүд рүү эгцлэн харж, бас тайван итгэлтэй хариулж байна. Харцанд нь балмагдсан, царайчилсан шинж огт алга, цаадахыгаа сонжин яс үзэлцэхэд бэлтгэж байгаа нь илт. Тушаал буулгадаг, илтгэл яриа хийдэг хүний тод сайхан дуутай аж. Чухамхүү энэ өөртөө эрэмшсэн дуу Шарокийн дургүйг хүргэнэ. Гэвч одоохондоо яая гэхэв.

Бусад асуултын дунд Рейнгольд сөрөг хүчинд хэрхэн оролцож байсан тухай асуув. Тэрээр ХҮ их хурлын өмнө явагдсан намын доторхи хэлэлцүүлгийн үеэр сөрөг хүчний байр суурийг дэмжиж байсан, гэхдээ удалгүй үзэл бодлоо өөрчилж, сөрөг хүчнээс бүрэн хөндийрсөн, түүнээс хойш тэдэнтэй ямар ч холбоо харилцаа байхгүй гэж хариулав.

Харин Шарок зөвхөн “Троцкийчууд-зиновьевчуудын сөрөг хүчинтэй нийлж байсан” гэж тэмдэглэв.

Тэгээд үзгээ тавьж,

-Та сөрөг үйл ажиллагааныхаа талаар арай дэлгэрүүлж ярина уу гэв.

-Юуны чинь үйл ажиллагаа вэ? Хэлэлцүүлэгт оролцохдоо сөрөг хүчний сэдвийг дэмжиж санал өгч байсан, дараа нь тэднээс салсан, дахиад эргэж нийлээгүй.

-Сөрөг хүчний төлөө санал өгч байхдаа та тэдэнтэй уулзаж байсан. Чухам хэн хэнтэй уулзаж байв?

-Нөхөр Шарок, энэ бол бараг арван жилийн өмнө болсон явдал. Миний хэргийг намын байгууллага хэлэлцсэн, тэнд би бүрэн дүүрэн тайлбар өгч байсан. Та түүнтэй танилцаж болно. Түүн дээр нэмж хэлэх юм байхгүй гэж Рейнгольд нухацтай хэлэв.

-Исаак Исаевич, та мөрдлөгийнхөнтэй зөрөлдсөнөөр байдал чинь сайжирна гэж найдаж байгаа бол эндүүрч байна. Та өөрийнхөө ашиг сонирхлыг бодож байгаа бол мөрдөн байцаагчтай хамтарч ажиллах хэрэгтэй хэмээн Шарок муухай царайлав.

-Ашиг сонирхлоо би өөрөө мэднэ, түүнийгээ өөрөө хамгаалах болно гэж Рейнгольд зөрж, байцаалтын тэмдэглэл рүү заагаад, -Та нарын иймэрхүү оворд би орохгүй. Би тэгдэг нь биш, гэнэн амьтныг мөн олов оо... Ер нь ямар ял тулгаж байгаагаа хэлэхээс нааш надаас нэг ч үг сонсохгүй гэж мэдээрэй. Би хуулийг танаас дутуугүй мэднэ шүү гэв.

Тэрээр Шарокийг тохуурхсан янзтай харав. Цаадах нь аль болохоор дугаа зөөллөн,

-Исаак Исаевич, би тантай зарим нэг зүйлийг тодруулах гэж ярилцаж байна, гэтэл та ял тулгахыг шаардах юм. Яллагдагч болох гээ юү? гэж асуув.

-Аятайхан ярилцах гэж байгаа бол намайг дуудан ирүүлж болох шүү дээ. Гэтэл би баривчлагдчихаад байна. Тэгэхээр намайг ямар нэг зүйлээр буруутгаж байх нь. Чухам юу вэ?

Шарокийн хувьд бүх зүйл тодорхой боллоо. Эцсийн аргуудаас л хэрэглэж таарах нь. Гэхдээ бас нэг оролдоод үзэх хэрэгтэй. Тэрээр санаа алдан, Рейнгольдыг өрөвдөнгүй харж,

-За яахав, Исаак Исаевич, та нэг зүйлийг тогтоож аваарай: Би тантай хэл амаа ололцохыг хичээж, ярьж тохиролцох гэж оролдлоо. Хэзээ нэгэн цагт та үүнийг ойлгож үнэлэх байх, тийм ээ, үнэлэх байх гээд учир битүүлэг царай гаргав.

Рейнгольд түүний өмнө хүчиндээ итгэсэн хүний илт тоомжиргүй дүртэй сууна.

-Та Каменевтэй сүүлчийн удаа хэзээ уулзсан бэ? гэж Шарок асуув.

Рейнгольд хямсайсхийв.

-Нөхөр мөрдөн байцаагч, та тулгаж байгаа хэргээ хэлээрэй!

Шарок хөмсөг зангидан, цаг хожих санаатай чимээгүй болов. Рейнгольд хэдийгээр их шийдэмгий байгаа ч тодорхойгүй байдал хэнийг ч зовооно шүү дээ.

Тэгж байснаа Шарок,

-Иргэн Рейнгольд! Миний ярьсныг тогтоож авсан байх гэж найдаж байна. Харин би одоо таны шаардлагыг биелүүлье. Ийм юм л даа. Та иргэн Каменевтэй уулзаж байсан тухай бидэнд гараа гарцаагүй баримт байна гээд дахин чимээгүй болов.

Рейнгольд ч дуугарсангүй.

-Энэ тийм үү, үгүй юү?

-Тулгаж байгаа хэрэг чинь энэ үү? гэж Рейнгольд зөрүүлж асуув.

-Тийм.

-Каменевтэй уулзаж байсан. Гэмт хэрэг нь хаанаа байна? хэмээн Рейнгольд дал мөрөө хавчив.

-Хаанаа байна гэвэл, Каменев нэг алан хядагч байгууллагыг толгойлж байгаа, түүндээ таныг татан оруулсан байна.

Рейнгольд сандал дээрээ цэх болж, анх удаа Шарок руу анхааралтай харав.

-Энэ тийм үү, үгүй юү?

Рейнгольд Шарок руу харсаар байв.

-Энэ тийм үү, үгүй юү? гэж Шарок дуугаа өндөрсгөв.

-Та ийм зүйл нээрэнхээсээ ярьж байна уу? гэж Рейнгольд асуув.

-Тэгэлгүй яахав. Мөрдлөгийнхөнд няцаагдашгүй, хөдөлбөргүй баримт байгаа юм чинь.

-Өө, тийм үү. Тэгвэл тэр баримтаа үндэслээд л намайг шүүж дээ гэж Рейнгольд хэнэггүй өчив.

-Шүүх юм бол буудан ална.

-Тэг л дээ.

-Амь нас чинь хайран биш үү?

-Хайран байлгүй яахав. Гэхдээ хийгээгүй хэргээ хэзээ ч би хүлээхгүй. Горьдсоны гарз.

-Таныг тагнуул, алан хядагч гээд буудан алвал танай гэр бүлийг юу хүлээж байгааг төсөөлж байна уу?

-Намайг бүү айлга. Намайг, манай гэр бүлийг та буудан алж болно, харин тэглээ гээд таны мөрдэсөнд ганц хөндөл нэмэгдэхгүй гээд Рейнгольд тамшаалав.

Шарок босч хонхоо дарав.

-За яахав, тун харамсалтай байна. Та хувь заяагаа өөрөө сонголоо шүү.

Үүдэнд харгалзагч орж ирэв.

-Аваад яв!

-Та болгооно уу, миний мэдүүлгийг яагаад тэмдэглэсэнгүй вэ? хэмээн Рейнгольд тэмдэглэл рүү заав.

-Та ямар ч мэдүүлэг өгөөгүй гэж Шарок хариулав.

-Гэхдээ намайг буруутгаж байгаа зүйлийг чинь би үгүйсгэсэн шүү дээ.

-Би танд ямар нэг ял албан ёсоор бичгээр тулгаагүй. Тэгэхээр та ч албан ёсоор мэдүүлэг өгөөгүй. Бидний нөхөрсөг яриаг тэмдэглэдэггүй юм. Би тантай нөхөрсгөөр ярилцсан, Исаак Исаевич, та үүнийг тогтоож аваарай, харин та надтай дайсагнасан байдлаар ярилцсан.

Тэгээд харгалзагч руу эргэж,

-Аваад яв! гэв.

Мөрдлөгийн бүх хэсгийн ажлыг Молчанов уялдуулж байгаа билээ. Тэрээр нэг өнжөөд мөрдөн байцаагчдыг өөр дээрээ цуглуулж, цаадуул нь дор бүрдээ мөрдөж байгаа хүнийхээ тухай илтгэдэг тул Шарок нийт мөрдлөгийн явцыг сайн мэдэж байв.

Ольберг хэрэгтэй зүйлийг шууд мэдүүлж, Троцкийн заалтын дагуу хүү Седов нь түүнд

Сталиныг алах даалгавар өгч Москва руу явуулсан гэдгийг хүлээжээ. Улаан талбай дээр жагсаал хийх үеэр Сталины эсрэг алан хядах үйлдэл хийхээр бэлтгэж байсан Горькийн сурганы дээд сургуулийн багш, оюутнуудыг аль хэдийн баривчлан Москвад авчирчээ.

Пикель хэрэгтэй мэдүүлэг одоо хэр өгөөгүй ч, Молчановын “Гай, Шанин хоёр учрыг олно” хэмээн жуумалзсанаас тэр тухайд бүх ёсоор болох нь гэдгийг Шарок ойлгожээ. Үнэхээр ч онцгой хэлтсийн дарга Гай, тээврийн хэлтсийн дарга Шанин хоёр элдэв ёсорхолгүй Пикелийн хоригдож буй өрөөнд орж гарч байгаад Зиновьевын эсрэг мэдүүлэг өгвөл амь насаа аврах төдийгүй эрх чөлөөтэй болно гэж ятган үнэмшүүлж чаджээ. Гэхдээ үүнийг Ягода нотлох ёстой гэж Пикель болзол тавьсныг ёсоор болгож, Ягода түүнийг хүлээж аваад нөгөө хоёрын амлалтыг давхар батлажээ. Энэ бүхнийг Шарок хожим олж мэджээ. Нэг удаагийн зөвлөлгөөний дараа Молчанов Вутковский, Шарок хоёрыг авч үлдээд, тэдний нууц улс төрийн хэлтэст ногдсон “тэслүүрүүдээс” ганцхан Рейнгольд мэдүүл-гээ өгөхгүй буйд сэтгэл дундуур буйгаа илэрхийлэв.

Шарок хэрхэхээ бодон биеэ хураав. Хэрэв Молчанов түүний байцаалтын тактикийг голж зэмлэвэл, тийм тактикийг Вутковский хэлж өгсөн гээд түүн рүү чихэж, түүнийг “худалдахаас” өөр аргагүй болно. Гэтэл Вутковский яг шулуухан тийм заалт өгөөгүй юм чинь өгсөн чиглэлээ үгүйсгэвэл яана. Тэгэх юм бол Шарок муу мөрдөгч төдийгүй яс хаягч болчихно.

Шарок дэмий сандарчээ. Вутковский түүний өмнөөс өөрөө хариулав:

-Мөрдлөгийн энэ шатанд, би эхний шатыг хэлж байна, Рейнгольдтой хатуу аргаар үзээд тус болохгүй. мань хүн их түрэмгий байгаа. Аргаа хослуулах хэрэгтэй. Мироновын хүмүүс түүнтэй жаа-хан үзэг. Тэд нар Зиновьев Каменев хоёрын хэргийг хөтлөж байгаа юм чинь. Бид Рейнгольдыг Каменевтай л холбох зорилготой шүү дээ. Болвол сайн хэрэг, болохгүй бол бидэнд буцаагаад өгчихнө биз.

Шарок Вутковскийг “эр хүн” гэж бодов. Ер нь Рейнгольдоос бүрмөсөн хагацвал мөн зүгээр сэн.

-Өө, тэгэлгүй дээ, Зиновьев Каменев хоёр Мироновт байгаа, Смирнов Мрачковский хоёр Гайд байгаа гэж Молчанов яхирлан егөв. -Харин тээврийн хэлтэс хэрэг дээрээ тоглоомноос гарсан.

Тээврийн хэлтэс яагаад тоглоомноос гарсныг Шарок мэднэ. Зам харилцааны ардын комиссараар томилогдсон анхны өдрөөсөө эхлэн Каганович өөрийнхөө аргаар сахилга, дэг журам тогтоож төмөр замын ажилтнуудыг тасралтгүй буудан алах болсноос тээврийн хэлтэс тэдгээр хэргийг ёс журмаар нь бүрдүүлж амжихаа болиод байгаа юм. Мэдээж, одооны шүүн таслах ажиллагааг бэлтгэх явдал гол зорилт, түүнд хамаг хүчээ төвлөрүүлэх ёстой, гэвч Ягода Кагановичтэй зөрчилдөхөөс айжээ.

-Бидэнд хэн нь үлдэж байна? гэж Молчанов асуув.

-Бидэнд хамгийн хүнд нь үлдэж байна. Шорон, хорихоос авчир-сан хэдэн зуун

троцкийчуудын учрыг олох ёстой, гэтэл тэд нэг ч удаа гэмшиж байгаагүй улс гэж Вутковский зөрөөд Молчанов руу их учиртай харав.

Энэ харцны учир тодорхой аж: Зиновьев, Каменев хоёр есөн жилийн турш гэмшихдээ жил ирэх тутам улам их нүглийг хүлээж байгаа, Киров алагдсаны ёс суртахууны хариуцлагыг тэд хүлээсэн, эрүүгийн хариуцлагыг ч хүлээнэ, үүнд эргэлзэх хүн байхгүй. Харин жинхэнэ троцкийчууд бол эвлэрэх хүмүүс биш, шорон, хориход улам хатуужиж, жилээс жилд дошгирч байгаа учраас нүцгэн гараар байтугай барагтай юмаар тэднийг нугалахгүй... Өөрснийгөө албан ёсоор ленинч-большевикууд гэж нэрлэдэг, гэмших нь битгий хэл

үзэл бодлоо нуудаггүй, Сталиныг ил муу хэлж, хувьсгалаас урвагч гэж зэмлэн буруушаадаг хүмүүсээс наад зах нь хорь, гучин хүнийг сонгон авч, тэднээр тагнуул, алан хядагч гэдгийг нь албадан хүлээн зөвшөөрүүлэх болж байна...

-Ер нь бол Рейнгольдын хувьд өөр гарц олж харахгүй байна гэж Вутковский дүгнэн өгүүлэв.

-Ажиллацгаа! гэж Молчанов урамгүй тушаав.

Сталин өөртэй нь хэн ч ярих гэсэн утас залгахгүй байхыг Поскребышевг тушаагаад, удахгүй болох шүүн таслах ажиллагаанд яллагдагчийн дүрд хүчээр тоглуулахаар Ягодын сонгон авсан Зиновьевчууд, троцкийчуудын нэрсийн жагсаалттай танилцав.

Зиновьевчууд гайгүй нь тодорхой байна. Гол толгойлогчид нь Зиновьев, Каменев, Бакаев, Евдокимов дөрөв, эднийг гүйцээж шахаад л бол оо.

Троцкийчууд төвөгтэй. Сокольников, Серебряков, Пятаков, Радек, Преображенский нар эрх чөлөөтэй, өнгөн дээрээ мөрөөрөө байгаа, тэднийг амжина. Шорон, цөллөгт байгаагаас хамгийн том нь Смирнов, Смилга хоёр. Чанга даа. Смилгад одоо хэр түлхүүр олдоогүй. Харин Смирнов бол... Сибирийн хувьсгалт хорооны дарга байсан, Колчакийг ялсан хүн, Троцкийн хувийн найз... түүний түлхүүр бол Мрачковский, Сибирьт цуг тулалдаж явсан дотных нь нөхөр.

Мрачковский нэг бус удаа шархадсан, битүү бэртэлттэй, голын хийтэй, адгуу, уцаар, хүлээцгүй хүн. Шоронд төрж, бойжсон. Эх нь хувьсгалч, эцэг нь, бас өвөө нь хүртэл Өмнөд Оросын ажилчны холбооны гишүүн явсан хүмүүс. Ийм гэр бүлд өссөн хэрнээ боловсрол маруухан, тогтвор муутай этгээд. Смирновын нөлөөгөөр Троцкийтэй нийлсэн, Троцкий ялвал түүнийг цэргийн хүнийх нь хувьд өөрийнхөө Ворошилов болгоно гэж горьдсон.

Тэрээр түүнтэй 1932 онд уулзаж, Смирновоос сал гэж ятгасан удаатай. Мрачковский үгэнд нь ороогүй ч тээнэгэлзэж байгаа нь харцаар нь илт байсан. Цаг яваад байдаг, мань хүн далд байгаад байдаг, тэгээд залхчихгүй юү... түүнийг жаахан шахаад өгөхөд бууж өгнө. Бууж өгвөл араасаа Смирновыг чирээд ирнэ, Смирновоос юу, яаж байцаахыг заагаад өгнө.

Гольцман энэ жагсаалтанд таарах этгээд. Хувьсгалын өмнө Англи, Францад цагаачилж явсан. Иргэний дайны үед Тухачевскийн командалсан 5 дугаар армид алба хашсан. Нэг хэсэг сөрөг хүчинтэй нийлж байгаад салсан. Иргэний дайны дараа Коминтернд ажиллаж байгаад хилийн чанадад дипломат ажилд томилогдсон, 1933 оноос одоо хүртэл Гадаад Хэргийн Ардын Комиссарын газар хариуцлагатай алба хашиж, гадаадад байн байн ажлаар явдаг хүн. Хилийн чанадад Троцкийтэй уулзсан байхыг хэн үгүйсгэх вэ? Тэгэхээр яг тохирох этгээд!

Дрейцер-Троцкийн хувийн хамгаалалтын албаны дарга, гэхдээ Ягодын хэлснээр бол найдвартай гэрч.

За, энэ Тер-Вагянан байна. Вышинскийн хувийн эвлэршгүй дайсан. Бүр хувьсгалын өмнө, Бакуд байхын түүнийг үзэн ядна. Тер-Вагянан большевик, Вышинский меньшевик байсан. 1915 онд яг тэр байдлаараа Москвад тааралдсан. 1920 онд Тер-Вагянан Вышинскийг баривчлахыг шаардсан. Чухам тэр үед Вышинский түүнээс аврал хайж ирсэн. мань хүн энэ бүхнээ сайн санаж байгаа. “Найз нар” шүүн таслах ажиллагаан дээр уулзацгааг.

Сталин дээрх гурвын нэрний ард тэмдэг тавив. Мөн өөр хориод хүний нэрний ард тийм тэмдэг хийв. Ийм тэмдэгтэйг илүү анхаарна гэсэн үг. Уул нь Сталин тэр хүмүүсийг их, бага ч гэсэн мэддэгийн хувьд л тэмдэглэжээ. Хүмүүс гэдэг бол аливаа хүмүүсийн адил сулхан

амьтад, тэднийг шахаад өгөхөд хэрэгтэй юмыг хэлж л таарна.

хүн сулхан амьтан, гэхдээ гагцхүү сулхан засгийн нүүрэн дээр л хүчтэй болдог. Хөрөнгөтний ардчиллын явуургүй нь үүнд байгаа юм. Дээд засаглал солигдож байх зарчим нь өөрөө тэр засгаа богино наслахаас өөр замгүй болгодог. Энэ түүнд таарахгүй. Дээд засаглалын өмнө хүн болгон арчаагүй амьтан гэдгээ мэдэрч байх ёстой.

Удахгүй болох шүүн таслах ажиллагаа үүнийг бүгдэд, түүний дотор дараачийн ажиллагаагаар шүүгдэх хүмүүст харуулах ёстой. Одоо болох ажиллагаа ирээдүйн ажиллагаануудад хүрэх тавцан гэдгээрээ чухал.

Үүнийг алан хядлага гэж нэрлэж болох уу?

Сталин шүүгээ рүү очиж, Энгельсийн ботийг гаргаад тэмдэглэсэн хуудсаа нээлээ. Энэ бол 1870 оны есдүгээр сарын 4-нд Энгельсээс Маркст бичсэн захидал.

“Алан хядлага бол айдаст автсан хүмүүсийн өөрсдийгөө тайтгаруулах үүднээс үйлдсэн ихэнхдээ учир утгагүй харгислал”.

Энэ бол эхнээсээ аваад эцсийнхээ үгийг хүртэл бүгд буруу.

Алан хядлага ашиггүй, учир утгагүй харгислалаас бүрдэнэ гэж байхгүй. Алан хядлага харгис нь үнэн, гэхдээ заавал учир утгатай, заавал эцсийн зорилготой байдгийн гадна алан хядлагыг дандаа ухаан алдтал айсан хүмүүс ч хийдэг юм биш. Харин ч болвоос айсан хүмүүс аллага хийж зүрхлэхгүй, байр сууриа бэхжүүлж чадахгүй байсаар дайсандаа бууж өгнө. Чухамхүү алан хядлага л Францын их хувьсгалын зорилтыг шийдэж, тэр хувьсгалаар үүссэн түүхэн үйл явцыг эргэлт буцалтгүй болгосон. Яг эсрэг юм нь юу вэ гэвэл, алан хядлагыг хэрэглээгүй учраас Парисын коммуна сөнөсөн. Парисын коммунаас нэг жилийн өмнө бичигдсэн Энгельсийн үг түүнд муугаар л нэмэр болж дээ.

Сталин өөр нэг шүүгээнээс Плехановын ботийг авч, мөн тэмдэглэсэн хуудсаа нээв...

“Алан хядлага гэж юу вэ? хэмээн Плеханов бичиж байна.

-Энэ бол улс төрийн дайснаа айлган сүрдүүлж, тэднийг айдаст автуулах зорилго бүхий цогц үйлдэл”.

Энэ тодорхойлолт алан хядлагын эерэг үүргийг нотлож байгаа учраас Энгельсийнхээс арай зөв, гэхдээ хангалтгүй. Энэ тодорхой-лолт алан хядлагын байг зөвхөн дайснаар, зөвхөн сөргөлдөгчөөр хязгаарлаж байна. Плеханов terror гэдэг латин үгийг айдас, аюул гэж их болхи ойлгож тайлбарлажээ.

Үнэн хэрэгтээ алан хядлага бол өөр үзэл бодлыг дарах арга хэрэглүүр төдийгүй бүх нийтэд хамаатай айдсаас үүдэн гарах нэгдмэл үзэл бодлыг тогтоох арга хэрэглүүр юуны өмнө мөн. Ард түмнийг өөрийнх нь ашиг сонирхлын үүднээс зөвхөн тэгж удирдаж болно. Ард түмний засаглал гэж хэзээ ч байгаагүй, хэзээ ч бий болохгүй. Ард түмнийг захиран засаглах гэж байж

болно. Үй олноор нууцаар залхаан цээрлүүлэх арга хамгийн их айдас төрүүлнэ, тэр л алан хядлагын гол арга болж байгаа, тийм ч байх ёстой.

Харин одоо ил тод бэлтгэлийг хангах явдал чухал. Улс орон даяар нэртэй хүмүүс гэмт хэргийн толгойлогч гэдгээ хүлээх явдал чухал. Тэд хичнээн их алдар цуутай байх тусам ард түмэн боловсон хүчний хувьсгал зөв гэдэгт, хүмүүсийг үй олноор солих нь зөв гэдэгт, алан хядлага гэж нэрлээд буй зүйлийн зөв гэдэгт төдийчинээ баттай итгэнэ.

Аж үйлдвэрийн намын хэргийг шүүн таслах ажиллагааны туршлага үүнийг нотлосон. “Хорлон сүйтгэгч” гэдэг үг заналт дайсан гэсэн утгатай болсон, одоо “троцкийчууд”, “зиновьевчууд”, “бухаринчууд” гэдэг үгс тийм утгатай болно...

Энэ үзүүлэх сургуулийн чанартай шүүн таслах ажиллагаанууд тун төвөгтэй, өөрийн гэсэн сул талтай, өөрийн гэсэн сөрөг талтай, гэхдээ эерэг үр дүн нь хавьгүй илүү, сайн тал нь хамаагүй их. Энэ үзүүлэх ажиллагааны сүр хүч, хэмжээ далайц, ач холбогдлыг хүний нэрнийх нь талаас ч, гэмт хэргийнх нь бүрдлийн талаас ч улам нэмэгдүүлж өргөжүүлэх хэрэгтэй. Кировын алуулсныг эцсийг нь хүртэл ашиглах хэрэгтэй, энэ бол үл хожигдох хөзөр, Киров төлөгдөж баршгүй гарз болох ёстой, түүний үхэл ирээдүйд явагдах бүх шүүн таслах ажиллагааны үндэс болох ёстой, яллагдагсад нь Кировыг алсан алуурчид, нам ард түмний заналт дайснууд болох ёстой. Одооны үзүүлэх шүүн таслах ажиллагаанууд даян дэлхийд дуулиантай лут арга хэмжээ болох ёстой. Хожмын бүх шүүх хурлууд хаалттай болно. Тийм учраас анхных л хамгийн чухал, тэр л бүтэмжтэй болвол бусад нь ч бүтнэ.

Үүний араас троцкийчууд, бухаринчууд, намын ихэрхүү түшмэд, эрх мэдэлд шунасан намын залуу хүнд сурталтнууд, ХҮП их хурлын хоёр нүүрт төлөөлөгчид, түүнийг уландаа хийхсэн гэж өдрийн бодол, шөнийн зүүд болж яваа ТХ-ны болон УТТ-ны гишүүд, муж районд, холбооны улс, төвийн яамдад буй тэдний найз нар, төлөөний этгээдүүд гээд урт гинж хөврөн гарч ирнэ.

1922 оны намын гишүүдийн тооллогоор намд 400 мянган хүн байснаас хувьсгалаас өмнө түүнчлэн 1917 онд элссэн гишүүн 11 орчим хувь буюу 44 мянга. Тэрээр энэ тоог сайн санана... 15 жил өнгөрөхөд тэднээс олон хүн нас барж, олон хүн троцкийчууд, зиновьевчууд, сапроновчууд, бухаринчууд гэдгээр намаас хөөгдсөн. Одоо хэд үлдсэн бол? 20 мянга, эсвэл хамгийн ихдээ л 30 мянга. Хуруу дарам цөөхөн! Хоёр сая гишүүнтэй намд хорьхон мянга! Ганц хувь! Нам тэднээр дутахгүй.

Тэрээр хэдэн түм, хэдэн буман найдваргүй хүмүүсийг хуу урсгаж, түүнд, зөвхөн түүнд үнэнч хүмүүст зам гаргаж өгөх их уруй буулгана. Тэдгээр үнэнч хүмүүсийн өмнөөс мань хүн зөвхөн мань хүн л бүх юмыг бодно. Боловсон хүчний энэ хувьсгал шинэ, жинхэнэ, хэн ч халдах ёсгүй, социалист байгууллыг бий болгоно. Боловсон хүчний энэ хувьсгал тасралтгүй үргэлжилж, ард түмнийг айдаст, албаны аппаратыг захиргаанд барьж байх болно.

Боловсон хүчний хувьсгалд үүнээс дутуугүй чухал бас нэг тал бий. Алан хядлага ард түмнийг үг дуугүй захирагддаг болгон хүмүүжүүлэхийн зэрэгцээ гарз золиосонд дасгаж, хүний амь нас хямдхан үнэ цэнэтэйг ухамсарлуулж, ёс суртахуун, зан суртахууны тухай хөрөнгөтний төсөөллийг ой тойноос нь арилгана. Тэгвээс ард түмэн элдэв эсэргүүцэлгүй захирагдана.

Хамтралжуулалтыг хэрэгжүүлж нударганчуудыг устгасан тэмцэл үүнийг гаргууд сайхан нотлосон билээ.

Одоо хамгийн хэцүү нь түшмэдүүд, тэднийг, хуучин боловсон хүчнийг, Будягин мэтийг эрхшээлдээ оруулах хэрэгтэй, тэднийг зөвхөн устгаж л эрхшээлдээ оруулна.

Удахгүй тохиох боловсон хүчний хувьсгалын хэмжээ далайцыг хэн ч төсөөлөхгүй. мань хүн л ганцаараа төсөөлж байгаа. Гэхдээ түүний эрин үе түүхэнд алан хядлагын эрин үе болж орох ёсгүй. түүний засаглал түүхэнд түүний удирдлагаар зөвлөлтийн ард түмний байгуулсан аугаа их ялалт ололтын эрин үе болж орох ёстой. Ард түмний сэтгэл зүрхэнд Тэрээр тууштай, шаардлагатай, шудрага, хүмүүнлиг захирагчаар үлдэх ёстой. Ардын дайсанд үнэхээр хайр найргүй хандана. Харин ард түмэндээ бол аргагүй уужим сэтгэлээр хандана. Нероныг нас барсны дараа түүний бүх хөшөөг хэмхэлж нураасан. түүний хөшөө дурсгалд ийм явдал тохиохгүй.

Залхаан цээрлүүлэх байгууллагын хувьд бас л засаглалын зарчмыг баримтлах хэрэгтэй: Тэднээс айж байх ёстой, гэхдээ бас хайрлах ёстой. Харин чекистийн эрэлхэг зоригийн биелэлийг ганцхан Зержинскийн нэртэй холбож байх хэрэгтэй. Зержинский нас барсан учраас түүнээс ямар нэг аюул гарахгүй.

Шарок дандаа нойр дутууг ч хэлэх үү, ер нь туйлдаж гүйцэж. Шөнө болгон байцаалт явуулна, өдөр болгон даргадаа илтгэнэ. Нэг өнжөөд Молчанов дээр зөвлөлгөөнд орно, шоронгоос авчирсан троцкийчууд мэдүүлэг өгнө гэж байхгүй, тэд нар ямар ч эрүү шүүлт, буудан алахаас ч айхгүй, Сталиныг үзэн ядна, аюулаас хамгаалах байгууллагыг үзэн ядна, мөрдөгчийн ганц ч үгэнд итгэхгүй, ямар ч өөш хаяж өгөөд нэмэргүй.

Энэ хараал идсэн ажил шуу юмнаас болоод Шарокийн үс хүртэл унаж эхлэв. Өдөр алгасахгүй шөнөжин байцаалт явуулсан энэ гурван долоо хоногийн дотор Тэрээр их өөрчлөгджээ. Шарок бүдүүлэг, мугуйд, муйхар харьцаж болох хүнтэй бүдүүлэг авирлана, мугуйдлана, муйхарлана, гэхдээ гараа бузарлахгүй хэмээн х а р а ж л ы г бусад хүнд, г ү й ц э т г э г ч д э д үлдээдэг байжээ.

Тэрээр бага байхдаа ч хариу цохилтноос айгаад хэзээ ч зодолддоггүй байсан, одоо хэрнээ тэр айдсаа гэтлэж эс чадна. түүний нүүрэн дээр байцаагдагчийг шалан дээр цохиж унагаад, резинэн бороохойгоор балбаж байхад мань хүн түүн рүү тонгойн толгойноос нь угзчин ялаа хүлээхийг шаардана. Гэхдээ хуучин бол өөрөө хэнийг ч унагадаггүй, бороохойддоггүй, өшиглөдөггүй байж.

Одоо бол өөрөө шалан дээр цохиж унагадаг, бороохойддог, өшиглөдөг болжээ.

түүний уурыг бүр 1927 онд намаас хөөгдсөн, намын ахмад гишүүн, Сибирийн цөллөгөөс хүргэгдэж ирсэн Лидия Григорьевна Звягуро шатаачихжээ. Сапроновыг дагагч, децист үзэлтэн тэд нар үнэхээр галзуу, улангасан зүтгэгчид, ёстой чонын бэлтрэг, нохойн гөлөгнүүд! Бүр ярилцахаас татгалзсан гээч.

-Миний хүү Тарас хаа байна?

Яасан ийснийх нь Тарас байдаг билээ? Хавтаст хэрэгт Тарас гэж юу ч алга, архиваас авчруулсан 1927 оны хуучин хэрэгт ч “тэр бүлийн байдал” гэсэн хүснэгтэд “Хүүхэд байхгүй” гэж тов тод бичээтэй байна.

-Танд хүүхэд байхгүй.

-Та яаж мэдэв?

-Таны 1927 оны байцаалтын хэрэг энэ байна.

-Тэр үед байгаагүй, одоо бол бий.

-Таны хүү хэдтэй болж таарах нь вэ?

-Долоотой.

Шарок түүнийг гайхшран ширтэв. Хүү. Долоотой. Энэ орсгой шүдтэй эрэмдэг чавганц руу

өнгийдөг хүн хэн бэ? Ямартай ч хүүхэд гаргачихаж. Гэхдээ хорих газар бол зуун настай ч бай, эм л бол хүүхэн шүү дээ, хорин долоон оноос хойш шорон, хорихоос салаагүй атлаа их гэдэслэж явдаг, ийм насан дээр шүү, хачин юм даа!

-Та жаахан оройтож хүүхэдтэй болж дээ.

-Энэ бол таны санаа зовох зүйл биш.

-Тэр ч мэдээж хэмээн Шарок инээх аядав. -Тэгээд хүү чинь хаа байгаа юм бэ?

-Би танаас асууж байна, миний хүү хаа байна?! Намайг Анга-раас Красноярск руу авчраад танай газрын өрөө рүү аваад ороход Тарасик дор, үүдэн дээр үлдсэн юм. түүнээс хойш би түүнийг хараагүй. Намайг хашаа руу гаргаж, машинд суулгаад галт тэргээр ийш нь, та нар руу авчирсан. Би замдаа өлсгөлөн зарласан, одоо ч үргэлжлүүлж байгаа, миний хүү хаана, яаж байгааг надад хэлж өгөхийг шаардаж байна.

Шарок түүнийг сонирхон харав. Өөрт нь нэг боломж гарч байх шиг. Энэ авгай шиг хүмүүс чинь улс төрийн төлөө хамаг амиа тавьчихаад төрөл төрөгсөдийнхөө хувь заяаг өчүүхэн ч тоодоггүй билээ. Гэтэл энэ чавганц зөвхөн улс төрөөр зогсохгүй бас хүүгийнхээ төлөө санаа тавьдаг байх нь.

-Та дэмий өлсөж байна, өлсгөлөнгөө зогсоо, үхвэл хүү чинь л өнчрөнө гээд Шарок бэх, тэмдэглэлийн дэвгрээ ойртуулав.

-Яг хэлнэ шүү: Хүүхдийн овог, нэр?

-Миний овог Звягуро, миний хүү Тарас Григорьевич.

-түүний баримт бичиг хаа байна? Төрснийх нь гэрчилгээ?

-түүнд баримт бичиг байхгүй, гэрчилгээ байхгүй.

-Яагаад?

-Энэ ямар хамаа байна?

-Лидия Григорьевна, би танд туслахад бэлэн байна хэмээн Шарок зулгуйдах мэт өгүүлэв. - Манай байгууллага эцэг эхийг нь тусгаарлахын хамт бага насны хүүхдүүдийг нь анхаарч халамжлах үүрэгтэй. Таны хүүхдийг ч бас халамжилсан байх. Хэрвээ тэгсэн бол бичиг баримтыг нь зөв бүрдүүлэх хэрэгтэй, тэгж гэмээ нь та хүүгээ хожим олж чадна. Хэрэв хүү чинь өөрөө тэр үүднээс яваад өгсөн бол бид эрэн сурвалжилна. Ингэхийн тулд түүний онцлогийг мэдэх хэрэгтэй.

-Ердийн л нэг хүүхэд, долоон настай, цайвар үстэй, цэнхэр нүдтэй, “р” үсгийг дутуу хэлнэ, цагаан цамцтай, хүрэн өмдтэй. Хөвөнгөөр доторлосон хөх цэмбэн пальтотой, зузаан саарал ороолттой, эсгий гуталтай... Өөрт нь баримт бичиг байхгүй, ер нь түүнд бичиг баримт байхгүй, Тарасик миний өргөмөл хүү, эцэг эх нь амь үрэгдсэн, би Сибирээс олж авсан юм.

Нэрээ Тарасик гэж мэднэ, намайг ээж-Лидия Григорьевна гэж мэднэ.

Бүх юм тодорхой боллоо. Зөнөсөн чавганц тэр Тарасдаа амь тавьдаг байх нь, одоо бүр солиорчихож, түүнийхээ төлөө яахаас ч буцахгүй дээ.

-Өргөж авсан бичиг баримтаа бүрдүүлсэн үү гэж Шарок асуув.

-Та хачин асуулт тавьж байна. Би яаж бүрдүүлэхсэн билээ? түүнийг тэмдэглүүлье гэхэд надад паспорт байхгүй. Гэхдээ миний цөллөгт байсан районы танай төлөөлөгч Алферов мэдэж байгаа, би түүнд албан ёсоор бичсэн.

-За, тун хэцүү хэрэг байна. Тэр хүүхдийг өөрийн гэх ямар ч албан ёсны эрх танд алга. Таны хүүхэд биш. Тийм учраас түүний тухай бид танд мэдээлэх албагүй.

-Тэр миний хүү, би түүнийг хүмүүжүүлсэн. Тэр ч намайг ээжийгээ гэж үздэг юм.

-Өө, тэгэлгүй яахав, хүний хувьд би таныг ойлгож байна гэж Шарок үгийг нь дагуулав. -Та хүүхдэд дасчихаж, тэр хүү ч танд дасчихаж. Гэхдээ албан ёсны зүйлийг би ч бай, хэн ч бай, хэрэгсэхгүй байх эрх байхгүй. Манай оронд хэдэн мянган хоригдол бий, бид тэгэхээр тэдний жинхэнэ, хууль ёсны төрөл төрөгсөдийн тухай л ярьж чадна. Биднийг ойлгоорой! хэн нэгэн хэнийг ч юм бэ, охиноо буюу хүүгээ гэж зүтгэхийг алийг тэр гэхэв! Тэр хүү өнчин юм байна, хүүхэд асрах газар очиж таарна гэж бодож байна, тэгээд л гүйцээ.

-түүний хувь заяаны талаар надад хэлэхээс нааш би өлсгө-лөнгөө зогсоохгүй.

-Өөрийгөө мунхаг байдалд бүү оруул. Таны өлсгөлөн зарласныг хэн ч анзаарахгүй. Нийтийн өрөөнд юун өлсгөлөн байх вэ дээ? Та нормынхоо хоолыг авдаггүй байж гэхэд хажуугийн чинь хүмүүс танд юм амхруулчихна. Одоо бол 27 он биш. Тэр үед өлсгөлөнг анхаардаг байсан, одоо бол та нарын өлсгөлөнг юман чинээ тоохгүй, та үүнийг үнэхээр ойлгохгүй байна гэж үү?

-Та яах л санж вэ. Миний хүү хаа байгаа тухай яг тодорхой лавлагаа өгөхөөс нааш би өлсгөлөнгөө зогсоохгүй, тантай юу ч ярихгүй гэж Звягуро тас зөрөв.

-За яахав, би олж мэдээд тэр чинь тэнд, тийм гэдэг хүүхэд асрах газар байна гэж танд хэллээ гэж саная. Тэгээд яах вэ?

-Хаа байгааг нь мэдэж байх болно. Одоохондоо тэгээд болоо. Та намайг буудан алж чадна. Гэхдээ би амьд байгаа цагтаа хүүгээ яасныг мэдэхийг хүсч байна, тийм эрх ч надад бий.

-Танд ямар ч эрх байхгүй, би тайлбарласан шүү дээ. Та хаашаа ч заргалдлаа гэсэн миний хүү гэж бичиж чадахгүй, тэр таны хүү биш, өргөмөл хүү чинь ч биш, зүгээр л хөндлөнгийн хүүхэд, тийм учраас таны гомдлыг хэн ч тоохгүй.

Шарок чимээгүй болж Лидия Григорьевнаг ажиглав. Ямар аймаар юм бэ, чөтгөр авмар! Даанч цуутай нэр-Звягуро! Хэдий-гээр одоо хасчихсан ч намын түүхийн сурах бичигт орсон нэр. Ийм хүнийг нугалчих юм бол ч Рейнгольд дээр бүдэрснийгээ засчихсан хэрэг болно.

Шарок сандлынхаа арыг налав.

-Лидия Григорьевна! Та ухаантай хүн, туршлагатай улс төрч. Таны гомдол ямар ч үр ашиггүйг та сайн ойлгож байгаа. Тантай санаандгүй таарсан өнчин хүүхдийг би эрж хайх албагүй. Тэр өлбөрч үхэхгүй, хүүхэд асрах аль нэг газарт түүнийг байрлуулчихна. Мэдээж, Звягуро гэдэг овгийг түүнд өгөхгүй, ямар овгоор, ямар газар очсоныг та хэзээ ч мэдэж чадахгүй. Энэ бүхнийг та ойлгож байгаа, гэхдээ үүнийг ойлгохоос илүү тэр хүүхдэд дасч л дээ. Энэ бол үнэхээр хүнлэг хэрэг, би таныг өрөвдөж байна. Та бидний энэ хэрэг явдал өнгөрнө, мартагдана, харин хүүхэд бол үлдэнэ. Та ч гэсэн түүнийхээ төлөө аж төрөх ёстой, Үзэл санаа, үзэл бодол чухал гэдгийг би ойлгоно, гэхдээ хүүхэд түүнээс ч чухал. Би танд шулуухан хэлье. Би хүүгийн чинь тухай олж мэдэх төдийгүй таныг хүү рүүгээ буцаж очиход чинь туслая. Харин та ч бидэнд тусал.

Звягуро толгойгоо унжуулан, хажуу тийш жишимгүй харсан чигээрээ суусаар.

-Та энэ байдлаараа байвал шорон, цөллөгнөөс өөр зам байхгүй. Юу болж буйг та харж байна. Намын эсрэг, з ө в л ө л т и й н э с р э г этгээдүүдтэй хийх тэмцлээ нам чангалж байна.

Шарок “зөвлөлтийн эсрэг” гэж зориуд цохон хэлжээ. Цаадуул нь тэднийг тэгж нэрлэхэд их дургүй, эсэргүүцэж сүйд болдог юм. Гэвч Звягуро таг чиг хэвээр.

-Намын эсрэг, зөвлөлтийн эсрэг этгээдүүдтэй хийх тэмцлийг нам эцэст нь хүргэнэ. Сөрөг хүчин ялагдахаа ялагдсан, тэдэнд ямар ч ирээдүй байхгүй. Нам, ард түмний хувьд та ямар нэгэн аюул мөн үү? Биш! Хуруу хөдөлгөх төдий та үгүй болно. Нам, ард түмэндээ эргэж ирж, социализм байгуулахад тусал л даа, чухам үүний төлөө л та хувьсгал хийлцсэн шүү дээ.

Шарок авгайн хэрхэхийг хүлээнэн үгээ таслав. Цаадах нь бахь байдгаараа толгойгоо унжуулан сууна.

-Таны юу гэж хариулахыг би мэдэж байна: Таныг аль хэдийн намын гишүүн болчихсон байхад би төрсөн, над мэт нь таныг ятгахгүй. Гэхдээ би таныг ятгаагүй, таныг нам ятгаж байна, ард түмэн ятгаж байна, тэгж яривал, таны зоргонд нь хаяж буй хүү чинь ятгаж байна гэж хэлж болох юм.

Тэрээр үгээ дахин таслав. Гэтэл энэ муу шулмын чавганц таг чиг толгойгоо унжуулсан хэвээр.

Нөгөө талаас ийнхүү чимээгүй байгаа нь Шарокт горьдлого төрүүлнэ: Сонсож байна, зөрөхгүй байна.

-Троцкийг улс төрийн хувьд аюулгүй болгоход та тусал. Тэр Зөвлөлтийн нутагт алан хядах, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулж буй бүлэглэлүүдийг хилийн чанадаас удирдаж байна. Москвад “Нэгдсэн төв”-өөр дамжуулан ажиллаж байсан. Тэр төвд нэг талаас Зиновьев, Каменев бусад зиновьевчууд, нөгөө талаас нэртэй троцкийчууд явсан Смирнов Мрачковский хоёр орж байгаа. энэ төвийн тушаалаар Кировыг алсан, нөхөр Сталин болон УТТ-ны бусад гишүүдийн эсрэг алан хядах ажиллагаа бэлтгэж байсан. Та энэ тухай огт мэдээгүй юу? Одоо

надаас мэдэж авлаа. Тэгэхээр Троцкий, троцкизмд эцсийн цохилт өгөхөд тусал л даа. Хуучин троцкийчууд, зиновьевчууд, децист явсан олон хүн бидэнд тусалж байна. Та ч гэсэн тусал л даа. Бид таныг шүүх гээгүй. Тийм алан хядах байгууллага байсан, алан хядах удирдамж өгч байсан гэдгийг л та гэрчилчихвэл бидэнд болоо. Хэзээ, хэнд, юу, яасныг та өөрөө мэдээд л хэлнэ биз. Энэ бол техникийн асуудал. Троцкий хилийн чанадаас Зиновьев, Каменев, Смирнов, Мрачковский болон бусад зарим хүнээр дамжуулан хуйвалдааныг удирдаж байсныг л хэлэх чухал... Бүх шудрага хүн бидэнд туслаж байна, та ч гэсэн тусал. Тэглээ гээд урвасан тэрсэлсэн юм болохгүй. Алдаатай чиг шугамнаас татгалзах, үр ашиггүй тэмцлээс татгалзахад айж ичих юм юу байхав. Харин ч амь насаа хамгаалж, тэгснээрээ өргөмөл хүүгийнхээ ч амь насыг хамгаална. Манай хүүхэд асрах газар, харамсалтай нь, ямаршуухан билээ, та мэднэ шүү дээ.

Звягуро чимээгүй байгаа нь Шарокийн дургүйг хүргэж эхлэв. Тэрээр дуугаа өндөрсгөлөө.

-Лидия Григорьевна! Би танд бүх зүйлийг тайлбарлалаа, хангалттай тодорхой тайлбарлалаа. Та сонголт хийх ёстой. Заавал одоо хариул гэж би шахахгүй. Тогтож бод, маргааш таныг дуудъя.

Авгай толгой унжуулсан чигээрээ,

-Тарас юу болох вэ? гэж асуулаа.

-Танаас нааштай хариу сонсонгуут би тэр даруй арга хэмжээ авна. Түүгээр барахгүй бид түүнийг Москвад авчирч танд үзүүлнэ, өргөж авсны тань баримтжуулна, хэрэв таныг хүсвэл төрөл төрөгсөд рүү тань явуулна, Ярославльд таны нэг зээ бий байх аа, Тарасыг түүн рүү явуулчихъя, болохгүй юм алга.

-Ойлгомжтой хэмээн Звягуро аяархан өгүүлэв. -Энэ инээдмийн жүжигт оролцохоос татгалзвал Тарасын тухай юу ч мэдэж өгөхгүй, түүний төлөө юу ч хийхгүй нь шив дээ.

-Ор тас юу ч хийхгүй гэж Шарок нотлов. -Таныг бидэнд туславал л бид онцгойлж үзэж танд туслана.

Шарок бараг өрөвдөж байна уу гэлтэй түүнийг тайван харж

байвч дотроо энэ муу шулмыг буулгаж авч дөнгөх нь гэхээс бах нь ханан хөх инээд нь хүрэх шиг. Амин газрыг нь ч аргагүй олжээ, тэр муу хүүгээ өөрөө хэлснийг яана!

Районы төлөөлөгч Алферов тэр Тарасын тухай юу ч бичээгүй, уул нь Звягуро өөрт нь бичгээр мэдэгдсэн юм байна шүү дээ. Хүүхэд үрчилсэн баримт мөрдлөгт хэр чухлыг ойлгох л ёстой доо, тэгсэн хэрнээ дурдаагүй байгаа юм. Яагаад? За яахав, учрыг олно оо. Энэ авгай бол хаашаа ч бултаж чадахгүй.

-Бусад хүмүүстэй та нар бас ингэж наймаалцдаг уу?

-Тэгдэг. Зарим нэг тохиолдолд. Ихэнхдээ элдэв наймаа шаард-лагагүй л дээ.

-Хүүхдээр барьцаалдаг байх нь.

-Лидия Григорьевна! гээд Шарок ширүүлээд ирлээ. -Надад хэлэлцүүлэг өрнүүлэх цаг байхгүй. Байдлаас гарах энгийн, шулуухан, зовлонгүй замыг танд би санал болголоо. хэн хэнд маань ашигтай зам. Шаардлагатай мэдүүлгийг бид танаас авч чадна гэдгийг та маш сайн ойлгож байгаа, бидэнд дажгүй зэгсэн арга хэрэгсэл бий. Би түүнгүй болгох гэсэн юм. Таны байдлыг сайн ойлгох учраас л би тантай ингэж зууралдаад байна. Миний болзлыг хүлээж авбал ав, авахгүй бол би таны амь нас, өргөмөл хүүгийн чинь хувь заяа хоёрын алийг ч хариуцахгүй шүү.

Авгай толгойгоо өргөн Шарок руу харав. Ийм муухай хорсолт харцыг Шарок хэзээ ч үзээгүй, Тэрээр айх шиг ч болж, бие нь хачин оргиод явчихав. Тэгсэн чинь нөгөө муу увайгүй өлөгчин чинь гэнэтхэн нүүр рүү нь нулимдаг байгаа даа, хэн тэгнэ чинээ санахав. Шарок огцом гэдэсхийж шүлс энгэр дээр нь туслаа. Ёстой муу үхдэл, шидэл!

Шарок босч нусныхаа алчуураар энгэрээ арчаад, Звягуро руу очиж толгойг нь өлийлгөв. Авгай шийдсэн царайтай өөдөөс нь харж байна. Шарок тэр зэвүүн хоншоор руу эхлээд зөв талаас нь, дараа нь солгой талаас нь хар хүчээрээ нулихад толгой нь хүүхэлдэйнх шиг санжганаад, орсгой шүдэт эрэмдэг чавганцыг хүн биш, ой гутам царай дортой сармагчин гэлтэй. түүнийг сандал дээрээс нь унагачихгүйн тулд хоёр талаас сэлгэн баахан балбав. Гэтэл нөгөө өлөгчин чинь ёйлох, уйлах аль нь ч байхгүй таг чиг, тэр битгий хэл, муу турсага чинь нүдээ ч анихгүй, нөгөө л хорсолт харцаараа түүнийг цоргисоор.

Эцсийн эцэст сандал дээрээс үхэдхийн уналаа... Шарок харгалзагч дуудаж, цаадуул нь түүнийг өрөө рүү нь чирч одов.

Шарок энэ шөнөөс хойш, Звягурог ийнхүү байцааснаас хойш мөрдөгдөгчдийг зодохоос эмээхээ больжээ. Нүүр рүү нь нударгалана, өшиглөнө, бороохойдно. Зодоод эхлэхээрээ улам догширно, гэхдээ тэг тэгсээр биеэ барьж сурчээ. Байцаагдагч бууж өгмөгц нүдэхээ больж, ширээнийхээ ард очиж, тамхиа асаан хэсэг зуур чимээгүй сууж амсхийнэ: зодох чинь хөнгөн ажил биш. Тэгээд байцаалтаа сэргээнэ. Мэдүүлгийг нь нэлээн гоморхсон царайтай тэмдэглэж авна. Өөрөө хүн зодоогүй, өөрийг нь хүн зодсон юм шиг. Тэр яллагдагч л албадаж байж ийм муухай ажил хийлгэсэн юм шиг.

Гэхдээ одоо хэр тун шалихгүй хүмүүс, хоёрдугаар зэргийн ч биш, гуравдугаар зэргийн хүмүүс л мэдүүлэг өгчээ. Тоймтойгоос хэн ч мэдүүлэг өгдөггүй. Шарок бодитой, мэдэгдэхүйц чухал үр дүнд хүрч чадсангүй. Тэгтэл нөгөө “тэслүүрийн” гурваас Ольбергээс гадна Пикель шаардлагатай мэдүүлэг өгч эхэлсэн, ганцхан Рейнгольд өгөхгүй байгааг Молчановын зөвлөлгөөн дээрээс олж мэдэв. Черток Рейнгольдтой гурван долоо хоног зууралдаж, юу эсийг хийсэн боловч мэдүүлэг өгөөгүй аж. Одоо Вутковский Шарок хоёрын “сахиусны” нөөц төлөвлөгөөг хэрэгжүүлэх ёстой болж байна.

Рейнгольдыг Шарокт буцааж өгчээ.

Тус албаны хамгийн аймшигтай мөрдөгч, алуурч, яргалан тавлагч Черток Рейнгольдын элдүүрийг нь хангахаар гурван долоо хоног ноцолдохдоо, өөрснөө ээлжлэн түүнийг дөчин

найман цагаар нойр, хоолгүй удаа дараа “туушиндаж”, хайр найргүй жанчиж, нүүрэн дээр нь авгай хүүхдүүдийг нь баривчлах зөвшөөрөл дээр гарын үсэг зурж элдэвлэсэн боловч юу ч хэлүүлж чадсангүй.

Гэхдээ анхны байцаалт дээр байснаас шал өөр Рейнгольдыг Шарок дээр авчирчээ. Нөгөө дэгжин костюм нь урагдаж нооройгоод, өлгүүрт өлгөсөн мэт үлхийж харагдана. Энэ гурван долоо хоногийн дотор мань хүн лав арван таван кило (Шарок нүдний багцаагаар үүнийг сайн баримжаална) турсан байх, сахал самбай нь ургачихаж, харц нь олон хоног унтаагүй, мөн төчнөөн хоног юм идээгүй, эрүү шүүлтэд нэрвэгдэж, доромжлуулж зодуулсан хүнийх шиг зэвэргэн гялалзана. Тэглээ ч гэсэн урьдын адил хорсол заналтай харж байна.

Энэ хорсол, занал түүнийг тарчлан зовоогсод руу, юуны өмнө Черток руу чиглэж байгааг Шарок сайн мэдэж байв. “Холимог аргын” гол утга нь ч энэ, эрүүлжүүлэх газар шиг халуунаас хүйтэнд, хүйтнээс халуунд шилжүүлнэ. Ийм “холимог арга” хэрэглэнэ гэж Вутковский Шарок хоёр зүтгэсэн бөгөөд одоо үүнийг амжилттай хэрэгжүүлэх хариуцлагыг тэд хүлээнэ. Тийм учраас маш нягт бодож боловсруулжээ. Хүчтэй арга хэрэгсэл ч бодож олж.

Шарок Рейнгольдод суухыг санал болгов.

-Исаак Исаевич, би тухайн үедээ таны мөрдөгч болох нь гэж найдаж, таньтай хэл амаа ололцоно гэж бодож байсан, гэтэл миний буруугаар биш, танаас болж бид хэл амаа олж чадаагүй. Черток дээр танд илүү байв уу? Үгүй л болов уу. Бид мань хүнийг сайн мэднэ.

Шарок Рейнгольд руу хувь заяа нь нэгэнт шийдэгдсэн хүн рүү, үхсэн хүн рүү харж буй мэт хийсвэр өрөвдсөн харцаар ширтэв. Тэгээд И.И.Рейнгольдод троцкийчууд-зиновьевчуудын хуйвалдаанд оролцсоны учир буудан алах, гэр бүлийн гишүүдэд нь Сибирьт цөлөх ял заасан ДЯАК-ын дэргэдэх Онцгой зөвлөлгөөний тогтоолыг түүн рүү сарвайв. Уг тогтоолд ДЯАК-ын том дугуй тамга даржээ.

Рейнгольд тэр цаасыг уншаад ширээн дээр тавьж,

-Би гарын үсэг зурах ёстой юу? гэж асуув.

-Мэдээж.

Рейнгольд харцаараа ширээн дээгүүр үзэг хайв.

Шарок түүний харьшгүй зоригийг гайхав. Зориг биш Чертокт тамлуулсандаа болоод үхэхийн түүс болсон байж ч мэднэ. Шарок түүнийг чимээгүй ажиглаж байснаа,

-Би танд нэг аятайхан зөвлөлгөө өгч болох байна, даанч та миний зөвлөлгөөг сонсох биш дээ гэж хэлэв.

Рейнгольд түүн рүү асуух маягтай харав.

Шарок хаалга руу хулгайн нүдээр харлаа. Онцгой итгэмжилсэн яриа болж буйг илтгэх хуучин арга.

-Нөхөр Ежовт биччих, юу бичих нь таны хэрэг, гэхдээ хэргээ эргэж хянаж үзэхийг чухалчлан гуйх нь мэдээж, тэгээд хамгийн гол нь ялын гүйцэтгэлийг хойшлуулж өгөхийг хүсэх хэрэгтэй. Үүнийхээ сэдэл шалтгааныг олно биз: гэнэт баривчлагдаж самгардсан, Чертокт байцаалгаж зүдэрсэн гэх мэтээс авахуулаад ер нь байдлаа эрэгцүүлж бодох хүсэлтэй байна, цаг хугацаа хэрэгтэй байна гэхчи-лэн. Та тэгээд үз л дээ. Таны өргөдөл нэг хоёр хоногийн дараа нөхөр Ежовын ширээн дээр очно гэдгийг би танд амлая. Нөхөр Ежов таны хэргийг эргэж хянаж үзэхийг даалгаж болохыг би үгүйсгэхгүй байна. Би танай өрөөнд цаас, бэх аваачиж өгөхийг тушаая, та өглөө гэхэд биччихнэ биз. Санаа нийлэх үү?

Рейнгольд дуугарсангүй.

-За, тэгвэл яахав, та өнгөрсөн удаа ч миний үгэнд ороогүй, тэгээд ийм юм авлаа гээд Шарок Онцгой зөвлөлгөөний хуурамч тогтоол руу заав. -Одоо бас орохгүй байна. Тоогүй л юм, энэ бол таны аминд хүрнэ дээ.

-За яахав, би бичье хэмээн Рейнгольд зөвшөөрөв.

Маргааш өглөө нь Шарок өөрөө Рейнгольдын өрөө рүү очив. ТХ-ны нарийн бичгийн дарга Ежовын нэр дээр бичсэн захидал бэлэн болжээ. Урт, будлиу захиа. Рейнгольд Төв Хороо, нөхөр Сталинд үнэнч гэдгээ тангараглаж; өөрийгөө буруугүй гэж зүтгэж; залуухан коммунист байхдаа сөрөг хүчний үзэл бодлыг хуваалцаж байсан тэрхэн хэсэг хугацааг хараан зүхэж; гэхдээ аль хэдийн чин сэтгэлээсээ салсан, Сокольниковын зуслан дээр үнэхээр очиж байсан, тэнд нэг удаа Каменевыг харсан, харин түүнтэй ямарваа нэгэн гэмт хуйвалдаанд нэгдээгүй. Хэргийг нь дахин хянаж үзэхийг хичээнгүйлэн гуйж байна, үхлээс айх юм байхгүй, үхэхэд бэлэн, гэхдээ намын дайсны хувьд биш, түүний үнэнч хүүгийн хувьд.

Шарок захиа, үзэг, бэхийг авч, хариу удахгүй гэж амлаад явжээ.

Тэрээр сэтгэл тун хангалуун байв. Бодсон төлөвлөгөө нь одоохондоо биелж байна, тасарлаа ч гэсэн энэ захидалд мань хүнээр хэлүүлж чадахгүй байсан олон зүйл байна: өнгөрсөн үеийнхээ үзэл бодлыг буруушаасан, Сокольниковтой дотно, шууд хэлхээ холбоотой, түүнчлэн Каменевтэй танил байснаа хүлээсэн байна. Үүнийг э х э н ү е д чамлах юу байхав.

Шарок шөнө нь Рейнгольдыг дуудуулав.

түүний царайд ханасан, баярласан, бүр хөөрсөн шинж илт.

-Исаак Исаевич, танд баяр хүргэе, нөхөр Ежов таны захидлыг уншсан байна.

Рейнгольд сэтгэл хөдлөсөн шинжгүй, тайван байна. Биеэ барьж сурсан хүн.

-Тэгэхээр ийм байна. ДЯАК-ын удирдлага таны захидлын тухай ТХ-ны нарийн бичгийн дарга нөхөр Ежовт илтгэсэн байна. Нөхөр Ежов ялыг цуцлах шийдвэр өгөхөөр зөвшөөрсөн гэнэ.

Шарок Рейнгольдоос харц салгахгүй байгаа боловч царайд нь ямар ч хувьсал олж харсангүй.

-Нөхөр Ежов ялыг цуцлах шийдвэр өгөхийг зөвшөөрсөн гэж Шарок давтан хэлэв. -Гэхдээ нэг болзолтой. Троцкийчууд-зино-вьевчуудын зандалчдыг бут ниргэхэд та мөрдлөгийнхөнд туслах ёстой. Ямар хэлбэрээр туслах вэ гэдэг бол техникийн асуудал, бид энэ тухайд тохиролцчихно, харин заавал туслах ёстой, нөхөр Ежовын болзол ердөө энэ. Хүлээн авбал ялыг цуцлана, авахгүй бол ялыг нэн даруй ёсоор болгоно.

Рейнгольд чимээгүй бодолхийлж байснаа гэнэтхэн өөрийнхөө хуучин дуугаар,

-За яахав. Би зөвшөөрье. Гэхдээ надад бас заавал шаардах нэг болзол байна: нөхөр Ежов буюу УТТ-ны аль нэг гишүүн Төв Хорооны нэрийн өмнөөс, надад ямар ч буруу байхгүй, гэхдээ намын эрхэм дээд ашиг сонирхол таны надаас нэхээд байгаа мэдүүлгийг өгөхийг шаардаж байна гэдгийг надад хэлэг гэж өчив.

Шарок сандлынхаа арыг гэдийн налж, их гайхсан царайтай Рейнгольд руу харав.

-Та өөрийгөө намын Төв Хороонд болзол тавих эрхтэй гэж үзэж байна уу?

-Тэгж байна.

-Та сөрөг болзол тавьснаараа хэрэг дээрээ, мөн чанартаа Төв Хорооны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан болж байна гэж айхгүй байна уу?

-Айхгүй байна.

-Та юу руу явж байгаагаа ойлгож байна уу? Та Төв Хороотой наймаалцах санаатай байна уу?

-Надад тийм санаа байхгүй гэж Рейнгольд эрсхэн зөрөв. -Нөхөр Ежовын шаардлагыг би түүнээс биш танаас сонсож байна. Та бол ТХ-ны нарийн бичгийн дарга биш, ТХ-ны төлөөлөгч биш, та бол мөрдөн байцаагч, тийм учраас таны үг миний хувьд ямар ч баталгаа биш. Намайг буудан ална уу, буцаагаад алуурчин Чертоктоо шилжүүлнэ үү, дураараа болцгоо, би яасан ч үгнээсээ буцахгүй. Болвол зөвхөн миний хэлснээр л болно.

Рейнгольд бууж өгөхгүйг Шарок ойлгож байв. Ёстой чанга хүн! Гэхдээ амжилт байна. Зарим болзлыг хүлээж авлаа. Энэ л гол нь, бусад зүйлийн учир олдоно.

-Би таны хүсэлтийг удирдлагадаа уламжлана гэж Шарок тоомжиргүй өгүүлэв. -Өнгөрсөн удаа та надад итгээгүй, хэрэг явдал Чертокоор дууссан, одоо дахиад итгэхгүй байна, энэ удаа юугаар төгсөхийг би мэдэхгүй. Гэхдээ давтан хэлэхэд, таны хүсэлтийг би яамны удирдлагад уламжлана.

Ингэж хэлээд Рейнгольдыг өрөө рүү нь буцааж, өөрөө Вутковскийд илтгэхээр гарлаа.

-За, тийм байж. түүнийг ойлгож болох юм. Гэхдээ Молчанов ам гарвал мань хүн сэтгэл нь ханах байх. Молчанов тэр хоёр хуучин танилуудыг ч хэлэх үү гэж Вутковский дүгнэв.

Гэтэл Рейнгольд Молчановын амлалтыг хүлээж авсангүй, өөрийнхөө болзлоос ухрахгүй гэж зүтгэжээ.

Рейнгольд ахмад коммунист, аж ахуйн томоохон зүтгэлтэн, Каменевын хувийн танил, ийм хүний мэдүүлэг Ольберг (Троцкийн явуулсан элч) Пикель (Зиновьевын нарийн бичгийн дарга) хоёрын мэдүүлэгтэй нийлээд шүүн таслах ажиллагааны найдвартай гэрчлэл болох учраас аргагүй чухал хүн, түүний шаардлагыг гарцаагүй хүлээж авна гэж Шарок итгэл төгс байжээ.

Гэтэл Шарок эндүүрчээ. Ягода Ежовт хандах асуудлыг сонсохыг ч хүссэнгүй. Тэрээр Рейнгольдыг хамтран ажиллахыг зөвшөөрөх хүртэл нь алах ялтай хүний байдалд барьж бай, гэхдээ удаах ёсгүй, гурав хоногийн дотор буулгаж авах хэрэгтэй хэмээн тушаал буулгажээ.

Шарок ширээнийхээ ард бодлогошрон сууна. Өмнө нь Рейнгольдын хэрэг бүхий шальчгар хавтас байна. мань хүн түүнийг мэдүүлгийн зузаан боть болгох ёстой. Энэ бол түүний сүүлчийн найдвар. Одоогоор нэг ч хүн улайлгаж чадаагүй, бусдынхаа сүүлийг барьж явна. Дьяков гэж нэг муу хүний адаг түүнд хамгийн егзөр, хамгийн цагаандаа гарсан этгээдүүдийг зориуд хуваарилж өгнө. Бодол нь ердөө төвлөрч өгдөггүй. Өнөө шөнийн бэрхийг хэлэх үү. Мэдүүлэг авах өрөө болгонд зодоон нүдээн, уйлаан майлаан. Нэмэрт нь, мухлаг хаалттай, тамхиа дууссан мөрдөгчид бие биенээсээ тамхи сураглаад салах юм биш. Шарок эхлээд гуйсан болгонд өгч байснаа, нэг харахнаа зургаахан ширхэг тамхитай үлдсэнээ мэдээд, өглөө болтол өөрт нь хүрэхгүйг ойлгон, тэр хэдийгээ ширээндээ нууж, асуусан хүнд,

-Байхгүй, байхгүй гэж хэлж байна шүү! хэмээн эгдүүцэн суув.

Гэтэл тэр давхрынхан мань хүнийг харамлаж байна гэж үзээд хаалгыг нь онголзуулсаар байв...

Шарок,

-Байхгүй, та нарт орос хэлээр хэлж байна, өөрөө ч татах юм алга гэж цаадуулыгаа шууд үүднээс хөөнө.

Тийнхүү хаалга дахин нэг онгойход мань хүн эргэж ч харалгүй,

-Тонил, ...охмор минь! Надад тамхи байхгүй! гэж уцаарлав.

Хаалга хаагдсангүй. Тэрээр эргэж харангуут айсандаа хувхай цайлаа. Үүдэнд нь жижигхэн хүн зогсож байв. Шарок түүнийг хармагц таньжээ... Энэ бол намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Николай Иванович Ежов.

Шарок ухасхийн босч цэрэг цамцаа засав.

-Нөхөр Төв Хорооны нарийн бичгийн дарга, ахлах төлөөлөгч Шарок илтгэж байна. Бүдүүлэг авирласныг минь уучлаарай. Би хэцүү хэрэг мөрдөж байгаа, гэтэл нөхдүүд маань тамхи гуйж зогсоо чөлөөгүй хаалга онголзуулаад байгаа юм. Би бүх тамхиа тараагаад дууссан. Дөнгөж зургаахан үлдсэн, гэтэл би өглөө хүртэл ажиллах ёстой.

Шарокийг илтгэх зуур Ежов дотогшилж, араас нь Агранов, Молчанов, Вутковский гурав орж

ирэв. Дарга нар шөнийн эргэлтээр явах нь элбэг, гэхдээ Ежов Шарокийн өрөөнд анх удаа орж ирж байгаа нь энэ.

-Та ямар хэрэг хөтлөж байна?

-Исаак Рейнгольдынх.

-Тэр чинь хэрсүү, хэрэгтэй хүн, чухал хэрэг байна. Явц нь ямар байна?

Шарок хоромхон зуур байдлыг үнэлэв. Одоо түүний хувь заяа, энэ байгууллага дахь түүний ирээдүй шийдэгдэх нь. Тэрээр Молчанов, Вутковский хоёрын хэн нэг нь илтгэх байх, Ежовын нэрийг зээлдсэнээс авахуулаад бүх болсон явдлыг тэднийг давж яаж өөрөө илтгэж болохов хэмээн бодознов.

Гэтэл нөгөө хоёр нь дуугардаггүй. Нууцгааж байх нь. Хэрвээ Ежов болсон явдлыг мэдчихвэл бүх юмыг өөр рүү нь, Шарок руу чихэж таарна, мань хүн л Рейнгольдыг байцааж байгаа юм чинь бүгдийг хариуцах ёстой. Тэгж бодмогц энэ мөчид хувь заяа нь шийдэгдэж байна гэсэн сэрэл нь улам эзэмдлээ. Ер нь ч хэзээ нэгэн цагт энэ мөч ирэх ёстой байсан.

Шарок төв дуугаар, тайван тод илтгэв.

-Рейнгольдын хэрэг тун удаан урагшилж байна. Тэр хамаатан Сокольниковынхоо зуслан дээр Каменевтэй танилцсан байна. түүний Каменевтэй ямар холбоотойг хэлүүлэх гэсэн миний оролдлого үр дүн өгөөгүй. Гүйцэтгэх хэлтсийн даргын туслах Чертокийн гурван долоо хоногийн байцаалт бас л үр дүн өгөөгүй. Рейнгольдыг надад буцааж өгсөн. Энэ хамсаатны ач холбогдлыг ойлгож байгаа учраас би эцсийн арга хэрэглэхээр шийдсэн: Би түүнд троцкийчууд-зиновьевчуудын хуйвалдааныг илчлэхэд бидэнд туслах санал тавьсан, тэгэхдээ татгалзах юм бол түүнийг буудан ална гэж урьдчилан сануулсан. Үүнийг хэлэхийн тулд би арга буюу Онцгой зөвлөлгөөний тогтоол үйлдэж түүнд үзүүлсэн. Гэтэл Рейнгольд хэрвээ та, нөхөр Төв Хорооны нарийн бичгийн дарга, хуйвалдааныг илчлэхэд түүний оролцох нь намын эрхэм дээд ашиг сонирхолд нийцэж байгааг түүнд нотлон хэлбэл миний саналыг хүлээж авна гэсэн. Харин би энэ асуудлаар танд хандаж зүрхлээгүй болно, нөхөр Төв Хорооны нарийн бичгийн дарга аа.

Ийнхүү илтгэж байхад Ежов өршөөлгүй цэвдэг харцаа Шарокоос салгасангүй. Дараа нь Агранов, Молчанов, Вутковский гурвыг ээлжлэн харав. Тэд нар нь Шарокийн энэ санамсаргүй, илэн далангүй мэдээлэлд мэл гайхаж, цэл хөхөрсөн юм байлгүй, таг чиг.

-Рейнгольдыг одоо над руу ирүүл гэж тушаагаад Ежов гарлаа.

Агранов, Молчанов, Вутковский гурав араас нь гарав.

Шарок ганцаараа үлдэв.

Тэрээр сандалдаа сууж, сая л амьсгаа авах шиг болов.

Ежовт илтгэж байхдаа ямар ч айдас мэдрээгүй. Тэр мөчид түүнд өөр гарц байгаагүй. хэн

нэгнийг хөөдчихгүйн тулд үг бүрээ л цэгнэн сонгож байсан. Хэрэв Ежов тодруулж асуусан бол мань хүн задлаж ярихаас өөр аргагүй болох байсан, магадгүй, Вутковскийг ч, Молчановыг ч нэрлэх, тэр ч байтугай Ягодаг ч нэрлэх байсан биз.

Ежов юу ч асуугаагүй, мань хүн ч хэнийг ч нэрлээгүй. Харин одоо Ежовын өрөөнд (тэр Ягодын өрөөнөөс холгүй албан бус өрөөтэй) тэр ч асуух юмаа асууж, Молчанов, Агранов эд нар ч цөмөөрөө нийлж байгаад турсагаа хамгаалцгаан, хамаг юмыг түүн рүү, Шарок руу чихэж байгаа даа... Ежов түүнийг яах бол, эсвэл Ежовыг явсны дараа Ягода яах бол бүү мэд, дор нь ялтан болгоод шоронд хийчихсэн ч чадна.

Хаалга онгойж, Ягодын зарлага ороод ирэх нь тэр. Энэ бол ардын комиссар дээр дуудсан гэсэн үг.

Шарок өндийлөө.

Зарлага наашлан ширээн дээр нэг юм тавив.

-Нөхөр Ежов танд өгүүллээ.

Тэгж хэлээд гараад явчихав.

Ширээн дээр нээгээгүй “Герцеговина флора” гэдэг тамхи хэвтэж байлаа.

Вадим тэгэхэд Альтманаас буцаж ирээд бүх зүйлийг эргэцүүлж бодсоны эцэст цочирдон балмагджээ. Арбатад, тэднийхээр орж гарсан хориод хүнийг нэрлэхийгээд, тэд нар анагаах ухаанаас өөр юу ч яриагүй гэж зүтгэж яаж болох вэ дээ. Энэ бол инээдэмтэй хэрэг. Альтман хувьсгалын эсэргүү яриа гэж шууд л хэлсэн. Энэ бол тэдний гэрээс ямар нэг юм тийшээ хүрсэн гэсэн үг... Харин чухам юу юм бол? Өөрөөс нь юу хүсээд байгаа юм бол?

Тэрээр Альтмантай дахиж уулзана гэхээс дотор нь харанхуйлна. Энэ алуурчин түүнд юу зэхэж байгаа бол? Нэг юмнаас эхлэснээ, шал өөр юм бодож, гуравдах юм руу үсчиж, гэнэдүүлж үг алдуулах гээд, үл мэдэгдэх байдалд байлган тороор хэрж байна...

Эсэргүүцэхийн тулд, ийм балай байдлаас гарахын тулд мань хүн хэргийн учир, түүнээс юу хүсээд, яах гээд байгааг яг тодорхой мэдэх хэрэгтэй. Ийм үл мэдэгчийн байдалд байх арга алга.

Тэрээр энэ тухай зогсоо чөлөөгүй бодно, өдөр ч, шөнө ч айдас салах юм биш. Юратай ярилцах хэрэгтэй. Багын найз, нөхөр юм чинь түүнээс юу хүсээд байгааг хэлж, тайлбарлаж өгөг. түүнээс туслалцаа, өмгөөл ивээл гуйхгүй. Вадим өөрийгөө хамгаалж чадна. түүний бүх амьдрал алган дээр буй мэт ил байна; тэр бол чин шудрага зөвлөлтийн хүн, жинхэнэ намч урлагийн төлөө тэмцэлд намын найдвартай туслагч, нөхөр Сталинд хязгааргүй үнэнч хүн.

Уул нь мань хүн хэнд ч, юу ч ярихгүй байх үүрэг авсан, гэхдээ Юра тэнд ажилладаг юм чинь түүнд хэлж болно. Дахиж дуудахаас нь өмнө бушуухан амжуулах хэрэгтэй. Юраг гэрээс нь олоход бэрх, гэхдээ ямар ч байсан олох ёстой.

Юра гэртээ байсан төдийгүй, өөрөө утсаа авч баярлан гайхав:

-Вадим уу? Ямар гээч гаригаас унаад ирэв ээ?

-Чи өөрөө л алга болчихож. Би байх газраа үргэлж байдаг хүн. Чам руу утасдсан, чи байхгүй л байх юм.

-Ажил ихтэй л байна.

-Уулзвал зүгээрсэн.

-Өө, тэгэлгүй яахав, би ч уулзмаар байна, ярих хөөрөх юм ч байна. Харин хэзээ яахав?

-Өнөөдөр уулзая.

Юра инээд алдав.

-Чөлөөт мэргэжлийн хүн гэдэг нь шууд мэдэгдэж байна. Өвгөн чинь орой болгон ажилтай, бүтэн сайн өдөр л үлдэж байна. Гэхдээ энэ бүтэн сайнд бас ажиллана. Дараачийн нямд утсаар ярьцгаая.

-Юра, тэр чинь оройтоно. Би чамтай заавал уулзах хэрэг байна. Яаралтай хэрэг.

-Хараач, бүтэн жил уулзаагүй байж гэнэтхэн яаралтай болчихдог байх нь ээ.

-Харин тийм ээ, Юра! Чамтай яаралтай уулзмаар байна.

-Юу болчихоов?

-Гойд юмгүй ээ. Гэхдээ чамаас зөвөлгөө авмаар байна.

-Би утсаар өгч чадна шүү.

-Утсаар ярих яриа биш гэж Вадим цөхрөн өгүүлэв.

Ингээд гишгэх газаргүй болох нь. Альтманыг дуудахаас өмнө түүнтэй уулзахгүй бол хамаг юм балрах нь тэр. Альтман хэзээ хэзээгүй утасдана.

-Юра! Хуучин нөхөр чинь ярьж байна шүү дээ. Чи ойлгооч! Надад энэ тийм чухал юм биш байсан бол би юу гэж чамд төвөг удах вэ. Эсвэл би чам дээр очих уу?

-Би ингэсхийгээд гарна. Ээж үдийн хоол халааж байна.

-Юра, тэгвэл манайд үдийн хоол идэцгээе гэж Вадим үнэхээр царайчилсан дуугаар хэлэв.

Шарок чимээгүй азнаснаа,

-За яахав, би арван минутын дараа утасдая. Очиж чадах эсэхээ хэлнэ гэв.

Тэгээд арван минутын дараа утасдав.

-Чиний ятгалганд автлаа, ингээд очно. Харин тухлах цаг надад байхгүй шүү, цугтаа түргэхэн хооллоцгооё.

Шарок уулзсандаа баяртай байгаа тул инээмсэглэн Вадимын дал руу алгадав.

-Чи ч бүдүүрээд л байх шив, Вадим. Зоогны сайхныг хөөгөөд галбираа бодохгүй байна аа даа.

-Хонгор минь, хэдий завандаа бодох вэ дээ.

-Мэдээж, чи бүх хүнийг үзэгнийхээ овоо хараанд авчихаад толгой дараалан балбах юм чинь... За юу гээч болчихоов?

Тэр хоёр хоолны өрөөнд ороход Феня тунгалаг шөл таваглаж өгөөд дийзтэй хуушуур дэргэд нь тавив.

-Онцын юм биш ээ. Би чамд шал дэмий төвөг удсан байх. Гэхдээ би тийм явдалд дасаагүй, хэзээ ч ийм байдалд орж яваагүй. Энэ бүхэн юу ч биш, надад ямар ч аюул нүүрлээгүй гэдгийг би сайн мэдэж байгаа ч, айхгүй ч гэсэн аягүй гэгч болоод байна.

Шарок инээд алдав.

-Хуульчид-биднийг бол бэлтгэсэн үгнийхээ эхний хуудсыг орхиод шууд хоёрдугаар хуудаснаас эхлэж бай гэж сургадаг юм.

-Юра, намайг Лубянка руу дуудаж уулзсан... гэж Вадим хэлэв.

Шарокийн царай доржноо хувьсхийв.

-Альтман гэж нэг хүн уулзсан, цол энэ тэрийнх нь учрыг би олоогүй, ер нь ч ойлгох биш, албархуу, хүйтэн царайтай, хөндий годил гэлтэй аймаар амьтан, би бүр тэнэглэж гүйцсэн, бодвол баахан мундраагий нь хутгасан байх. Тэндээс л бушуухан гарахаас өөр ямар ч хүсэл надад байгаагүй.

түүний хоолой чичирхийлэв. Юра түүнийг үнэхээр өрөвдөхгүй байна гэж үү?

Цаадах нь царай нь хүчилсэн чигээрээ, Вадимыг эгцлэн харахгүй чимээгүй сууна.

Феня шагайв.

-Тугалын махаа өгөх үү?

-Аваад ир гэж Вадим бувтнаад хаалга хаагдахыг хүлээнэв. -Ер нь бол, тэнд нэг их онцгой юм болоогүй, танил гадаадын хүний тухай л асууж байна лээ. Би мэдэх бүх хүнээ нэрлэсэн, тэр бичиж авсан, надаар гарын үсэг зуруулсан, тэгээд явуулсан. Гэхдээ дахиж дуудна гэсэн. Тэгээд яах гэж байгааг нь би ойлгохгүй байна. Надаас юу хэрэгтэй юм бол? Гадаадынхантай хийсэн хэрэг, ярьсан зүйл надад байхгүй, чи намайг мэдэх юм чинь... Вика Франц явсны тухайд бол би ямар хамаа байна?

Тэгтэл Шарок гэнэтхэн соотосхийгээд ирэв.

-Франц руу явсаан? Яах гэж?

-хүнтэй суугаад л яваад өгсөн.

-хэнтэй суугаав?

-Нэг сурвалжлагчтай.

-А-аан, зөвлөлтийн эсрэг үзэлтэнтэй гэж Шарок бувтнав.

-Тэр зөвлөлтийн эсрэг үзэлтэн юм уу? Чи мэдэх юм уу?

-Коммунист сонины сурвалжлагчдаас бусад нь бүгд зөвлөлтийн эсрэг үзэлтнүүд. Коммунист сониныхонд ч гэсэн тэгтлээ итгэж болохгүй.

Тэр хоёр тугалынхаа махыг идэцгээв.

-Тэгээд хэргийн учир чухам юу юм бэ? гэж Шарок асуув.

-Намайг тийш чирч байхын жинхэнэ шалтгааныг би ойлгохгүй байна. Яасан гэж? Аав дээр орж гардаг гадаадынхны төлөө юу? Гэтэл тэд чинь албан ёсоор ирдэг, тэднийг албаны хүмүүс дагаж явдаг шүү дээ. Тэгвэл юу вэ? “Та хэнтэй эсэргүү юм, зөвлөлтийн эсрэг юм ярьсан бэ?” гэж асуусан. Юун яриа вэ? Би хэнтэй ч тийм юм ярьсан байх ёсгүй. Би чинь шудрага зөвлөлтийн хүн.

-Үгүйдээн ганц удаа зөвлөлтийн эсрэг ямар нэгэн юм хэлээгүй зөвлөлтийн иргэн гэж байхгүй хэмээн Шарок айлдав.

“Үгүй, мөн ярив аа” гэж Вадим бодож амжив.

-Тэгвэл би онцгойрох юм байна, тийм яриа ярьдаггүй учраас. Тэр Альтмантай мэтгэлзэнэ гэхээс надад үнэхээр яршигтай байна. Би уул нь Зохиолчдын эвлэлийн удирдлагад, эцсийн эцэст Алексей Максимович Горькийд ч хандаж болох л доо, даанч би тэнэгтэж

байгаад энэ тухай хэнд ч ярихгүй гээд Альтманд амлачихсан юм.

Шарок ширээн дээгүүр бөхийн, Вадимын нүүр рүү нүүрээ ойртуулав.

-Чи тийм амлалт өгсөн юм уу?

-Тийм.

-Тэгвэл яагаад надад ярив?

-Гэхдээ чи бол т э н д ажилладаг шүү дээ гэж Вадим дахин будилснаа ойлгох зуур хулчгар өчив.

Шарок тавгаа огцом түлхлээ.

-Чи намайг ямар байдалд оруулснаа ойлгож байна уу?

-Юра...

-Юра, Юра... хэмээн яг Альтман шиг түүний үгийг дургүйцэн давтав. -Юуны чинь Юра?! Чамд и т г э с э н байна, чи ярихгүй гэж а м л а с а н байна, чи үүргээ з ө р ч с ө н байна. Би тэнд ажилладаг юм гэнэ... Би ямар ажилтайг чи мэдэх үү?! Хашаачин ч юм бил үү?

Тэрээр дахин чимээгүй болж хэсэг азнаснаа,

-Би энэ байгууллагын ажилтан, надад албаны нууцыг хэллээ, би энэ тухай даргадаа илтгэх үүрэгтэй гэж баргар царайлан өгүүлэв.

Вадим самгардан яах учраа олохгүй дэмий л түүнийг харж суув.

-Тийм шүү гэж Шарок эгдүүтэй үргэлжлүүлэв. -Би албан үүргийнхээ дагуу тэгэх ёстой. Чи надад хэллээ, өөр хэн нэгэнд хэлэхгүй гэсэн баталгаа хаа байна? Аягүй бол “Миний нэг танил тэнд ажилладаг, би түүнд ярьсан, тэр намайг аргална” гэж нэмж хэлэх байлгүй.

-Юра, яаж чи ингэж ярьж чадаж байна аа?

-Чадахгүй байхдаа яадаг юм? Чи намайг ийм ацан шалаанд оруулж байгаа юм чинь би яасан ч чадна!

-Юра, чи надад итгэ...

-Би үүргээ биелүүлэх ёстой. Манайх онцлог байгууллага учраас энэ тухайд холбогдолтой бүх юмыг ажилтан болгон даргадаа илтгэж байх үүрэгтэй.

Тэрээр ширээний араас босч, цагаа харав.

-Миний явах цаг болчихож.

-Юра, чи үнэхээр тэгнэ гэж үү?

Шарок түүн рүү харалгүй,

-Бидний яриаг чи хэнд ч дамжуулахгүй гэж амлах уу? гэж шижээргүй асууснаа, -Би асуугаад байхдаа ч яахав дээ, чи чинь Альтманд ч амлаж байсан шүү дээ гэв.

Вадим гараа зүрхэн тус наманчлан дарав.

-Чамд андгайлъя... хэнд ч, ганц үг ч цухуйлгахгүй. Чамаас өөр хэнд ч, юу ч хэлээгүй, надад итгэ. Миний хэлэхээр шийдсэн хүн

бол ганц чи. Би бодохдоо...

Шарок түүний үгийг тасдав.

-Чи юу бодсоноо хэлсэн, давтахын хэрэггүй. Миний нөхөрсөг зөвлөлгөө гэвэл, цааш нь бүү орооцолдуул, байцаагдсан тухай ч, надтай уулзсан тухай ч, хэнд ч, юу ч бүү ярь. Чалчихаа боль, өнөө хүртэл яаж аж төрж байсан, тэр янзаараа аж төр, эс тэгвэл чамд ямар нэг явдал тохиож гэж гадарлачихна, тэгээд албадаж яриулна.

-хэн гадарлаж, хэн албадах юм бэ? гэж Вадим гайхшрав.

-Хэрэгтэй хүн нь гэж Шарок нухацтай хариулав. -Чамайг зүгээр нэг дуудах ёсгүй. Зүгээр нэг хийдэг юм манайд байхгүй, хүмүүст дэмий төвөг удахгүй, ялааг заан болгохгүй. Чамайг дуудан байцааж, протокол хөтлөөд, энэ талаар зарлах ёсгүй гэж сануулсан бол хэрэг байна гэсэн үг, ноцтой хэрэг. Чиний эргэн тойронд байгаа хүмүүс үнэн хэрэгтээ хэн бэ гэдгийг чи

мэдэх юм уу?! Чамд ялихгүй зүйл гэж санагдаж байна. Ялихгүй зүйл биш! Чи ч тэр, эцэг чинь ч тэр, зөвлөлтийн эсрэг юм яриагүй гэдгийг би маш сайн ойлгож байна. Гэтэл чи зөвхөн гэртээ хүн хартай уулзахгүй шүү дээ. Чи их олон хүнтэй уулзаж байгаа, чи маш олон танилтайг би сайн мэднэ, Вадик. Тархи толгойгоо сайн онгич Тэрээр Вадимыг анхааралтай сонжин харснаа,

-Ярьсан юм уу, сонссон ч юм уу ганц онигоо, тэгээд л зүйл анги бэлэн шүү гэж цаанаа л нэг учиртай хэлээд шинелиэ өмсөж, товчоо товчлов.

-За, байхгий!

Ямар ч атугай горьдлогын гэгээ зурсхийлээ. Шарок эр хүн, ямар ч гэсэн жинхэнэ найз. Зовж явахад нь хаясангүй. Хэрэг явдал онигоотой холбоотойг битүүхэндээ ойлгуулж өглөө. Ээ, тэнгэр минь, онигооноос болж сүйрэх хэрэг үү?

Тэрээр сүүлийн үед сонссон онигоо, мааз яриануудыг нэхэн саналаа. Шальтай юм алга. түүний санаанд орсноос Радек Сталин хоёрын тухай ганц онигоог их бага хэмжээгээр эрүүгийн холбогдолтой гэж үзэж болох юм. түүнийг хэнээс сонслоо? Эльсбейн, утга зохиол судлагч Эльсбейн, яг мөн, түүнээс сонссон. Вадим зохиолчдын клубын ресторанд ахмад нөхөр, өөрийг нь ивээгч Ершиловтой цуг үдийн хоол идэж байсан. Тэгэхэд Эльсбейн хазганан ирж тэдний ширээнд суусан. Ершилов сандал татаж өгсөн, Вадим түүнд дургүй учир ярвайсхийж суусан. Нүд нь гялганаж, худлаа инээсэн хачин этгээд.

-Шинэ онигоо мэдэх үү? гэж Тэрээр асуусан. -Сталин Радекийг дуудаж ирүүлээд ингэж хэлж: “За хө, Радек, чи онигоо зохиох дуртай, миний тухай бас зохиодог гэлцэх юм. Тийм бол тэгж болохгүй, би жолоодогч гэдгийг бүү март!” Радек тэгсэн чинь: “Чи жолоодогч оо! Энэ онигоог чинь би хүнд хараахан яриагүй юм байна” гэж хариулжээ.

Ершилов инээмсэглэсэн, Вадим ч бас инээмсэглэсэн, Эльсбейн босч цаашаа явсан.

Вадим тэгэхэд энэ явдлыг нэг их тоогоогүй. Тэгээд ч энэ онигоог өөр хүнд өөрөө яриагүй шиг санагдах юм.

Байз, үгүй ээ, ярьсан юм байна... Үсчин Сергей Алексеевичид, энд Арбатад, Калошиний өнцөг дээрх үсчинд ажилладаг, Вадим бүр багаасаа мэддэг ө ө р и й н х ө ө үсчин Сергей Алексеевичид ярьсан. Аавд нь аль хувьсгалаас өмнө үйлчилж байсан, одоо ч үйлчилж байгаа түүний байнгын үсчин. Эцэг нь бие муу байлаа гэхэд Сергей Алексеевич гэрт нь ирээд л үсийг нь засч, сахлыг нь хусч өгнө, талийгаач ээж нь Вадимыг түүн рүү дагуулж очиж үсийг нь засуулна, эрүүндээ гоё сахалтай, сайхан зантай, хүнд дандаа сайн санаж явдаг, харваас буурьтай толиотой хүн... Жаахан байхад нь сандлынхаа хоёр тохойвчин дээр жижигхэн банз хөндлөн тавьж түүнийг суулгаад, “За, залуу гуай” энэ тэр гэж тоглож байгаад л үсийг нь засна... Хожим ээж нь нас барж, ганцаараа очдог болсон, тэгээд өнөөг хүртэл үсээ мань хүнээр л засуулж яваа. Сергей Алексеевич Вадимын өгүүлэл, шүүмж нийтлэгддэг сонин сэтгүүлийг уншдаг нь юу л бол, гэхдээ түүний амжилтын тухай наад зах нь Фенягаас дуулахаараа нэг дуулсан байгаа. Феня тэр хоёр нэг тосгоных бил үү, төрөл ч гэдэг бил үү, ямар ч атугай Сергей Алексеевичийн зөвлөснөөр тэднийх тэр авгайг үйлчлэгчээр анх авсан

билээ.

Вадим найзан дундаа өвгөнд янз бүрийн улс төрийн сонин дуулгаж, хэвлэлийн мэдээ сэлтийг тойруулж элдвийг тайлбарлана. Дээгүүр зиндааны хүн болж харагдах санаатай л тэр.

Сергей Алексеевич жогтой нь аргагүй магнайгаа үрчийлгэж байгаад сонссон бүх юмаа, “Лев Давыдовичгүй бол болдоггүй ээ” хэмээн хар муу санаагүй ганцхан өгүүлбэрээр дүгнэнэ. Троцкийн тухай энэ өгүүлбэр нь “муу л бол баруун хойт талын хар овоохой” гэдэгэрхүү сонсдоно.

Сергей Алексеевич Радекийн тухай онигоог сонсоод эелдэгхэн инээмсэглэж, бахь байдгаараа “Лев Давыдовичгүй бол болдоггүй ээ” хэмээсэн, уг ухаан нь Сталинд тийм хоржоонтой хариу өгөхийг Троцкий Радект зааж өгсөн байх юм биз дээ.

Үнэхээр Сергей Алексеевич алтан хошуу өргөлөө гэж үү? Эцгийг нь хориод жил мэдэх, талийгаач ээжийг нь ч мэдэх, Вадимыг өөрийг нь ч бараг өлгийтэй байхаас мэдэх, ер нь гэр бүлийн гишүүн гэж хэлж болохоор ойр дотны хүн шүү дээ. Эсвэл мань хүн ерөөсөө мэргэжлийн мэдээлэгч юм болов уу? Хэдэн арав, зуун хүн түүний гараар орно, хэл ам нь загатнасан амьтан алийг тэр гэхэв, яг аятайхан газар юм биш үү.

Феня нударганы хүүхэд. Гэтэл Сергей Алексеевич тэр хоёр хамаатан. Вадим үүнийг яагаад тоохгүй, бодолцохгүй явав аа? Гэр бүлийн найз. Өөрийн хүн. Ер нь мань хүн бүх Арбатынханд өөрийн хүн. Тэгээд бүгдийнх нь талаар “мэдээлэл” бичдэг биз. Вадимын тухай, өөрийнх нь тухай ч бичээгүй гэх газаргүй.

Вадим Зохиолчдын клубт Эльсбейн, Ершилов хоёртой тааралдах-даа царайг нь нарийн ажиглана. Ямар нэгэн сэжиг мэдэгдэнэ шүү дээ. Гэтэл нөгөө хоёр нь байдгаараа л байна. Гэхдээ хэн нэгэн хүн түүнийг ховлосон нь лав.

Эльсбейн үү? Эльсбейн бараг өдөр болгон Каменевинд очдог, тэр хоёр “Academia” хэвлэлийн газар хамтарч ажилладаг байсныг бүгд мэднэ. Каменевыг шоронд хийсэн, тэгсэн хэрнээ Эльсбейнд гар хүрээгүй. Гарцаагүй хачин зүйл. Нөгөө талаас онигоог Эльсбейн өөрөө ярьсан юм чинь юу гэж өөрийгөө ховлох билээ.

Ершилов уу? Ершилов тийм зиндааны хүн биш, арчаагүй хов хөөцөлдөхгүй. түүний мэргэжил-том хов, түүний шүүмж болгон улс төрийн хов, түүний зад шүүмжилсэн өгүүлэл болгон мөн чанартаа ялын төлөвлөгөө. Тийм арчаагүй, тийм шалихгүй юмаар мань хүн хөөцөлдөхгүй.

Ингэхээр, хэрэг явдал чухамхүү тэр онигооноос болж байгаа бол зөвхөн Сергей Алексеевич л түүнийг ховлосон хэрэг.

Ингэхээр мань эр, Вадим Марасевич, зөвлөлтийн эсрэг онигооны түгээгч болсон, түүнийгээ хаа ч хамаагүй үсчний газар хүртэл тарааж явдаг гэсэн үг. Дүү нь зөвлөлтийн эсрэг үзэлтэнтэй суугаад Парис явчихсан, мань хүн энд зөвлөлтийн эсрэг явуулга хийж байх нь.

Гэтэл тийм биш! Үгүй! мань хүн зөвлөлтийн эсрэг үзэлтэн биш! Тийм онигоог Сергей Алексеевичид ярьсан нь, мэдээж, тэнэг хэрэг, тэгэх тусмаа мань эр тэр онигоог ойлгосон нь юу л бол. Энэ чинь Сталины тухай биш, Радекийн тухай онигоо шүү дээ.

Вадим өөрийгөө яаж ч тайтгаруулж, тайвшрууллаа гэсэн хэрэг явдал нь базаахгүй, ер нь маш муу байгааг ойлголгүй яахав. Альтман шууд л нөхөр Сталины тухай онигоо ярьсан л гэнэ. Хаана гээч? Үсчингийн газар! хэнд гээч? Үсчинд! Өөр хэнд ярьсан бэ? хэнд ч яриагүй. Өө, хэнд ч яриагүй юу, бид яахаараа танд итгэх ёстой билээ?

Ямар аймшигтай юманд орооцолдоо вэ. Одоо юуг ч үгүйсгэж чадахгүй, үгүйсгэх нь мунхаг хэрэг, буруугаа улам л даамжруулна.

Гэтэл энэ онигоог Сергей Алексеевичид ярьснаа хүлээх юм бол хэнээс сонссоноо хэлэх ёстой болно. Эльсбейнийг нэрлэх ёстой болно, тэгвэл хэн байлцсан бэ? гэнэ. Ершилов. түүнийг ч бас нэрлэх хэрэгтэй болно. Хэрвээ нууж, булзааруулаад байвал мань хүнийг шоронд хийчихнэ.

Шоронд үнэхээр хийх болов уу? Тэгвэл амьдрал дуусах нь тэр. Юуны төлөө сөнөх ёстой болж байна, дөнгөж хорин тавтай хүн чинь! хэний төлөө?! Тийм онигоо зохиодог Радекийн төлөө юу, түүнийг нь тарааж явдаг Эльсбейны төлөө юу? Радект зовох юм алга, миний нэрийг зээлдэж байгаа юм гээд л хэлчихнэ. Ер нь ч түүний нэрийг их зээлддэг юм чинь. Тэр муу нохойн гөлөг, өдөөн хатгагч Эльсбейн тийм онигоо ярина, зүгээр ч үгүй гуравдах хүний, Ершиловын нүүрэн дээр шүү. Ершилов ч гэсэн дээ! Намын гишүүн, түүгээр ч зогсохгүй намын хорооны гишүүн, тэгсэн мөртлөө Эльсбейнд яагаад няцаалт өгсөнгүй вэ? Няцаалт өгсөн бол Вадим дорхноо сэхээ авч, өөрөө бас няцаалт өгөх байсан төдийгүй Сергей Алексеевичид тэр онигоог ярихгүй байхгүй юу. Эльсбейн Ершилов хоёр ч ёстой таарсан хоёр юм даа. Тэднийг өөрөө ч бас хамгаа-лахгүй. Альтман бушуухан дуудаасай. Яах, юу болох нь бүү мэд байх чинь яасан хэцүү юм бэ?

Тийм ээ, бушуухан л дуудаасай. Вадим гэрээс гарахгүй утсаа чагнана, хэрэг гарвал хэн ярьсныг асууж, нэрийг нь бичиж авахыг Феняд хатуу даалгана. Феня нэр тэмдэглэж авахгүй, Вадимын уур шатчихна.

-Чамд би орос хэлээр хэлсэн шүү дээ, бичиж авч бай гэж. Утасны дэргэд харандаа цаас зориуд тавьсан. Хэдэн тахир үсгээ зурчих тийм хэцүү байна уу?

Гэвч Феня “тахир үсэг зурахыг” хүсэхгүй, нэг эрэгтэй хүн утасдсан, хэн гэдгээ хэлээгүй гэж маргааш нь илтгэнэ.

-Чи асуусан юм уу?

-Асуусан, гэтэл тэр хүн утсаа тавьчихсан.

Эсвэл ингэж хэлнэ:

-Нэрээ хэлээгүй, хэзээ байх вэ л гэж асуусан.

-Чи тэгээд юу гэж хариулав?

-Юу?! Орой гэртээ байна л гэсэн.

-Долоон цагт байна гэж хэлэхийг би чамд тушаасан шүү дээ.

-Би харин долоод л гэж хэлсэн.

-Мөн хэлнэ дээ чи! Чи юу ч хэлээгүй!

-Үгүй, хэлсэн.

Гэхдээ тэр Альтман яагаад утасдахгүй байна? Чөтгөр алгадмар! Амралтаа авсан юм болов уу, эсвэл тэр хэргийг хаачихаа юу... Юрка Альтманд “Би Вадим Марасевичийг мэднэ. Тэр бол манай залуу, манай хүн!” гэж хэлээ биз.

“Манай залуу, манай хүн!” Найдвартай үгс, лут үгс. Тэрээр т э д н а р түүнийг ө ө р и й н х, өөрийн залуу, өөрийн хүн гэж үзээсэй гэж байнга хүсдэг билээ. “Манай нөхөр” биш, чухамхүү “манай хүн” гэж хэлүүлэхийг хүснэ. “Нөхөр” гэдэг бол завсрын, зуурдын зүйл, харин “хүн” гэвэл тогтвортой, үүрдийн зүйл.

Бодвол, Юрка яг л “Манай залуу, манай хүн” гэж хэлсэн байх, тэгээд Альтман нөгөө балай протоколоо хог руу шидчихсэн хэрэг. Юрад утасдаж тандвал зүгээрсэн, даанч эвгүй юм, бас Юра ч юм хэлэхгүй, онигооны тухай битүүхэн хэлсэн нь их юм, чухамдаа ингэх ч эрх байхгүй шүү дээ.

Нэг, хоёр сар өнгөрч, амьдрал дассан сурсан байдалдаа эргэж оров. Вадим ч тайван эргэцүүлэх болж: Альтман амралтаа авсан гэж саная, тэгвэл аль хэзээний ажилдаа орох болчихсон, гурван сарын амралт гэж манайд байхгүй. түүнийг ажлаас нь халчихсан байж магадгүй, тэгвэл бүр л сайн биз, түүний оронд арай ухаантай хүн ирээд, Вадимын хэрэг зохиомол зүйл гэдгийг дор нь мэдэрч бүрэн хаасан гэсэн үг. Хамгийн гол нь Юрка түүний тухай м а н а й залууг тайван байлга гэх ухааны нэг л нааштай юм гарцаагүй хэлж дээ.

Вадим бүрмөсөн тайвширчээ. Сонин сэтгүүлд түүний өгүүллүүд дахиад жирэлзэх болж, мань хүн индэр дээрээс дахиад ниргэж, илчилж гарлаа.

Дээдчүүл нь сэтгэл хангалуун байна. Владимир Владимирович Ермилов хүртэл,

-Эр хүн, зүйтэй сэтгэж байна! хэмээжээ.

Рейнгольд Ежовтой ярилцсанаас хойш шал өөр хүн болчихжээ. Тэрээр одоо хуйвалдагсадыг зад илчлэхийн зэрэгцээ Шарокийн шаардсан бүхэн дээр гарын үсэг зурж байгаа төдийгүй мэдүүлгээ улам хурц, улам үнэмшилтэй болгох олон зүйлийг өөрөө нэмж байв.

Ежов түүнд юу амласан, тэр хоёр юу гэж тохирсоныг Шарок зөвхөн таамаглахаас цаашгүй. Амь насыг нь хэлтрүүлэхийг амласан, буруугүйг хүлээн зөвшөөрсөн, намын хүсэл зоригийг мэдэгдсэн-энэ бүхэн тодорхой, гэхдээ хэний нэрийн өмнөөс бол? Ежов өндөр нэр хүндтэй, гэхдээ Рейнгольд түүгээр ханасан уу, эсвэл түүнд бүр дээгүүр хүний хүсэл зоригийг уламжилж мань хүн өөрийгөө нам-улсын чанартай том ажиллагаанд оролцогч гээд саначихав уу? мань хүн протоколд Шарокийн тэмдэглэснийг илүү зохистой, илүү овжин томъёололоор сольж, “та ингээд биччих” гэнэ.

Тэрээр троцкийчууд-зиновьевчуудын хуйвалдаанд оролцогч мөн, Зиновьев, Каменев, Бакаев нарын удирдлагаар ажиллаж, Сталин түүнчлэн Ворошилов, Каганович зэрэг нам, төрийн бусад удирдагчийг алах бэлтгэлийг хийж байсан гэж мэдүүлжээ. Мөн Зиновьевын шууд заалтаар Кировыг алсан гэдгийг нотолжээ.

Ийнхүү Рейнгольд гол “тэслүүр” болж, түүнийг мөрдөж байгаа Шарок бусдаас ялгарахуйц мөрдөгч болж хувирав.

Пикель Ольберг хоёр Рейнгольдын мэдүүлснийг яг нотлосон лугаа адил Рейнгольд тэр хоёрын мэдүүлгийг бас давхар нотложээ.

Молчановын тушаасан ёсоор Рейнгольд, Пикель, Ольберг гурав эдийн засгийн хэлтсийн дарга Мироновын өрөөнд уулзаж, мэдүүлгээ хооронд нь тулгаж зохицуулжээ.

Тийнхүү зохицуулсан, нэг нь нөгөөгөө тодотгож нотлосон, Молчанов, Ягода энэ тэр хичээнгүйлэн нягталж шалгасан, Шарокийн таамаглаж буйгаар бол бас нөхөр Сталинд илтгэсэн сайхь гурвын мэдүүлгийг одоо гол яллагдагсад болох Зиновьев, Каменев хоёр, түүний хамсаатнуудад тулгах бөгөөд тэр мэдүүлэг ирэх шүүн таслах ажиллагааны үндэс болох ёстой.

Шарок нэг удаа Вутковскийтэй ярилцаж байхдаа Рейнгольдын ийм хачирхам дуулгавартай байгаад гайхаж буйгаа хэлжээ.

Ухаалаг, хашир Вутковский бодосхийснээ,

-Рейнгольд өөрийнхөө өмнө тулсан зорилтыг намын зорилт гэж ойлгож байна. Үүнд чин санаанаасаа итгэж байх шиг санагддаг юм. Ер нь өөлөх юмгүй лут хүн дээ гэж хариулжээ.

Шарок тэр хариултад үнэмшиж буй царай гаргажээ. Вутковский Рейнгольд хоёрын ялгаа юу вэ? Нэг нь домог зохиож, нөгөө нь тэр домогт итгэж байгаа дүр эсгэж байна. Үүнийгээ намын эрх ашгийн үүднээс хийж буй мэт дүрслэнэ. Шал худлаа! Аль аль нь турсагаа л аварч буй хэрэг. Шарок өөрөө ч гэсэн турсагаа хамгаалж байгаа, харин мань хүн бол намын эрх

ашиг гэгчээр хаацайлаагүй, гагцхүү албан үүргээ биелүүлж байгаа, өөр юу ч байхгүй. Тэрээр даргынхаа даалгаврыг биелүүлж байна, гэхдээ сохроор биш, хууль, заавар журмын дагуу ажиллаж байгаа, хууль гаргасан хүн, заавар журам батласан хүн л хариуцлагаа хүлээх ёстой.

Хамгийн дээд хууль бол Сталин. Сталины ашиг сонирхолд нийцэж байгаа л бол бүх юм зөв. Шарок коммунистуудыг насан туршдаа үзэн ядаж яваа. Ганцхан хүнээс бусдыг. Тэр нь Сталин. Сталин өөрөө коммунистуудыг, ялангуяа ахмад коммунистуудыг хяргаж байгаа, уул нь энэ диктатурын сүр хүч нь тэд байсан, яагаад гэвэл тэд нар өөрснөө бүгдийг хайр найргүй хядаж байсан, одоо өөрсдийнх нь ээлж ирж дээ, хөөрхий, Сталин тэднийг ёстой нугалж өгч байна, зуу наслах болтугай. Шарок өөрийгөө энэ тогтолцоотой үүрд холбосон, тэгэхээр энэ тогтолцооны хөдөлбөргүй бат бэх байхаас өөрийнх нь амь амьдрал шалтгаална. Тэрхүү хөдөлбөргүй, бат бэх байдлын баталгаа нь Сталин, гагцхүү Сталин. Чухам тийм учраас Сталины ашиг сонирхлын үүднээс хийгдэж байгаа бүхэн зөв.

Рейнгольд энэ л эцсийн дүгнэлтийг удирдлага болгож байгааг Шарок ойлгох төдийгүй мэдэрч байгаа билээ. Шарок түүний мэдүүлгийг Ежовт биечлэн илтгэнэ. Молчанов, Агранов хоёрын хэн нэг нь байлцдаг ч гэсэн мань хүн л илтгэнэ. Ежов мэдүүлэгтэй танилцах явцад Рейнгольд зарим үдэшлэг, уулзалт дээр Смирнов, Мрачковский, Тер-Вагянан, Дрейцер энэ тэртэй тааралдаж явснаа дурдаагүй байгааг анхааруулжээ.

-Яагаад ч юм бэ, тэдний тухай юм хэлээгүй байх юм хэмээжээ.

Далд санааг нь ойлголгүй яахав. Дараачийн байцаалт дээр

Рейнгольд хуйвалдаанд Зиновьев, Каменев хоёр төдийгүй, Иван Никитич Смирнов, Мрачковский, Тер-Вагянан нарын троцкийчууд, түүнчлэн Рыков, Бухарин, Томский гурав оролцсоныг мэдүүлж, протоколд гарын үсэг зуржээ. Шарок тухайлан өгсөн тушаалын дагуу Рыков, Бухарин, Томский нарын нэрийг тусгай протоколд тэмдэглэж авчээ.

Рейнгольд, Ольберг, Пикель гурвын мэдүүлэг шүүн таслах ажиллагаагаар шүүгдэх гол буруутнуудыг яллах зөвхөн ү н д с и й г бүрдүүлж байгаа билээ. Алан хядах хуйвалдаанд орсон жирийн оролцогчдын мэдүүлэг бас хэрэгтэй. Шорон, цөллөгнөөс авчирсан сөрөг хүчнийхэн мэдүүлэг өгдөггүй хэвээр. Молчанов ажил олигтой урагшлахгүй байгааг сайтар мэдэрсний эцэст бүр Ежов даргыг оролцуулсан зөвлөлгөөн хийлгэв.

Шарок Дьяковын даалгавраар Ленинград явсан тул тэр зөвлөл-гөөнд оролцоогүй. Ежов тэгэхэд, ирэх шүүн таслах ажиллагаа улс орны хувьд, намын хувьд, олон улсын коммунист хөдөлгөөний хувьд онцгой чухал ач холбогдолтой болно. Мөрдөн байцаагчид ардын дайснуудтай хайр найргүй тэмцэх хэрэгтэй, одоо мөрдөгдөж байгаа б ү х хүн ардын дайсан гэдэгт Төв Хороо, Улс төрийн Товчоо, нөхөр Сталин өөрөө бат итгэлтэй байгаа гэж хэлжээ.

Валентин Ольберг Горькийн сурганы дээд сургууль дээр түүний байгуулсан алан хядах бүлэгт оролцсон багш, оюутнуудын дотор түүхийн багш, коммунист Соколов, тайж гаралтай, хаант засгийн францад сууж байсан элчин сайдын ач, химийн багш, нам бус Нелидов хоёр бий гэж мэдүүлсний дагуу тэднийг авчирсан билээ.

Дьяков Нелидовыг амар хүн байх ёстой, түүний туслалцаатай троцкийчуудыг хаант засгийн язгууртнуудтай холбож дөнгөнө гэж бодоод, өөрөө түүнийг байцаахаар шийдэж, Соколовыг Шарокт өгчээ.

Гэтэл Дьяковын санаснаас тэс өөрөөр эргэжээ. Соколов туршла-гатай суртал нэвтрүүлэгч учраас шүүх хурал Троцкий, Зиновьев, Каменев нарын эсрэг чиглэсэн үйлдэл болно, шүүгч нар зөвхөн Сталины хүсэл зоригийг биелүүлнэ, мань хүн өөрөө яаж ч цааргалаад ашиггүй гэдгийг сайн ойлгож байж. Тэрээр мөрдлөгийнхний зорилтыг ойлгож байгаа, өөрөө туслах үүрэгтэй гэж Шарокт мэдэгджээ.

Тэдний сургуулийн оюутнууд Сталиныг чухам ямар аргаар алах гэж байсныг Шарок тодруулья гэсэнгүй. Элдэв юм зохиогоод эхлэвэл ерөөсөө алах санаа байсан эсэхэд эргэлзэхэд хүргэнэ. Товчдоо, Соколовын учир амархан олдож, мань Шарок маргааш өглөө нь гэхэд түүний мэдүүлгийг Вутковскийн ширээн дээр тавьчихсан байв.

Нелидов Дьяковын тааснаас өөр хүн болж таарав. Төрөл саднаас нь амьд хүн бараг үлдээгүй тул тэднийхээ төлөө санаа зовно гэх юмгүй. Намын гишүүн байж үзээгүй учраас намд сүжиглэх шүтэх юм даан ч байхгүй.

Шарок нэг удаа Дьяков дээр орохдоо Нелидовыг харжээ. Тэрээр гучин тав эргэм насны, өргөн магнайтай, ухаалаг нүдтэй залуу юмсанж. Дьяковоос жаахан эмээгээд байгаа юм уу гэмээр Шарокт санагджээ. Цаадахь нь ажил бүтэлгүй буй учраас айхтар дошгирч, уул нь биеэ барьж чаддаг энэ тэр ч хаа байхав, галзуу солиотой мэт авирлан Нелидовыг харааж зүхнэ. Нелидовын айсан царай гэмшсэн инээмсэглэлээр солигдовч юунд ч гарын үсэг зурдаггүй хэвээр.

Энэ мөрдлөг бүтэлгүйтэж унавал Дьяков дарга нартаа гологдох, аягүй бол төв аппаратаас халагдаж мэдэх аюултай. Дьяковын хувьд тэгсэн нь бараг дээр гэж Шарок үзнэ. Дьяков өөрөө бол тэгж үзэхгүй, шинэ нөхцөл байдалд ажиллах чадвартай гэдгээ ямар ч байсан нотлохыг хүснэ. Төдөлгүй нэг боломж гарчээ. Ямар ч атугай эхлээд тэгж санагдаж.

Ольбергийн мэдүүлснээр бол Горькийн сурганы дээдийн оюутнууд нөхөр Сталиныг гар буугаар буудаж алах санаатай юм байж.

Энэ хувилбарыг хэлэлцэх үед тэнд байсан хилийн цэргийн газрын дарга Фриновский инээд алдав.

-Мавзолей дээр зогсож байгаа Сталиныг Улаан талбайгаар яваа жагсаалын дундаас гар буугаар онох хэрэг үү? Ямар зай байгааг та нар мэдэх үү? Та нарт алсын тусгалтай гар буу байгаа юм уу, үзүүлээч, би бол ерөөсөө дуулаа ч үгүй юм байна. Цагдаа нарын бүслэлтийг та нар үзээгүй юу? Тэд чинь Мавзолей руу ойртуулах нь битгий хэл, нэг ч хүнийг жагсаалаас гаргахгүй. Горькийн сурганы дээдэд мэргэн буучид байдаг байх нь. Тэднийгээ надад өгчих, би тэднээр чинь бүхэл бүтэн дивизээ сольчихье.

Фриновскийн зөв гэдгийг бүгд ойлголгүй яахав. Ер нь мөрдлөгийнхөн баргийн утга учиргүй юмыг тоохгүй л дээ, гэхдээ л Мавзолей руу гар буугаар буудна гэдэг бол үйлийн үргүй

үнэмшилгүй зүйл.

Дьяков босч өөр хувилбар санал болгов. Бөмбөг! Тэрээр химийн багш Нелидовыг мөрдөж байгаа, тэр этгээд сургуулийнхаа химийн лабораторид бөмбөг хийхэд яагаад болохгүйсэн билээ? Нелидов адарч ярдаглаад мэдүүлэг өгөхгүй байгаа нь үнэн, гэхдээ түүнд гэрчийн мэдүүлэг тулгаж, э д м ө р и й н нотлох баримт үзүүлэхэд бүх юмаа хүлээхгүй хаачихав.

Энэ санаа Молчановын сэтгэлд нийлжээ. Нэгдүгээрт, гар буунаас бөмбөг нь хавьгүй үнэмшилтэй сонсдож байна, хоёрдугаарт, эд мөрийн н о т л о х б а р и м т ы н тухай дурдах нь чухал, яагаад гэвэл энэ бүх хэрэгт ерөөсөө ямар ч эд мөрийн нотлох баримт байхгүй, гагцхүү яллагдагсадын хэрэг хүлээсэн мэдүүлэг л байгаа. Сургуулийн лабораториос ямар нэг тэсрэх бодис гарцаагүй олдоно.

Дьяков хэсэг ажилтны хамт тэр даруй Горкий руу явж, төдөлгүй буцаж иржээ. Тэгээд Молчановын ширээн дээр 6-7 см-ийн голчтой хэдэн хөндий төмөр бөмбөлөг тавьж, энэ бол бөмбөгний гадар хэмээгээд тэнд үйлдсэн зохиомол албан бичгээ уншиж сонсгожээ. Тэрхүү бөмбөгний гадарнуудыг алан хядагч оюутнууд хожим тэсрэх бодисоор цэнэглэхээр тухайн үедээ сургуулийн хашаан дотор нуусан болж таарав. Энэ бөмбөлөгнүүд бөмбөгний гадар үнэхээр мөн, тэсрэх бодисоор дүүргэх юм бол тийм бөмбөг ихээхэн сүйтгэх чадалтай гэсэн дүгнэлт Горкий хотын цэргийн комендантаас гаргасныг Дьяков мөн уншиж сонсгов.

Энэ албан ёсны дүгнэлт сүрхий сэтгэгдэл төрүүлэв. Гэхдээ бүх хүнд биш.

Онцгой хэлтсийн дарга Гай нэг бөмбөлгийг барилж үзсэнээ хямсайн тамшаалав.

-Энэ бөмбөлгийг татаж хуушуур хийхэд хэр зэрэг таарах вэ, бөмбөг хийхэд яг тэр хэмжээгээр таарна. Ямар ч их буучин ингэж хэлнэ, ямар ч тогооч үүнийг нотлоно.

Зовлонтой чимээгүй байдал үүслээ. Гэхдээ Молчанов алан хяд-лагыг улам найдвартай илчлэхийн тулд шүүх дээр “бөмбөг” үзүүлэхийг үнэхээр хүсч байгаа бололтой, аягүй бол энэ тухай д э э ш нь хэдийн илтгэчихсэн, одоо ухрах газаргүй болчихсон ч байж магадгүй. Тэрээр Дьяковт,

-Энэ бөмбөлгүүдийг Нелидовт үзүүлж тулга, хэрвээ цааргалаад байвал түүнийг над дээр авчир гэж тушаав.

Молчанов хажуу тийш Шарок руу харснаа,

-Нөхөр Дьяковт та тусал гэв.

Энэ бол Дьяковт өгсөн сануулга. түүний захирдаг хүнд өөрөөс нь илүү итгэл үзүүлж байна.

Нелидов бөмбөлөгнүүдийг хараад инээд алдсанаа, ийм юм бөмбөг хийхэд яагаад я м а р ч хэрэггүйг тайлбарлажээ.

Нелидовт энэ бөмбөлөгнүүдийг үзүүлсэн нь тактикийн том алдаа гэдгийг Шарок ойлгож байв. түүний эсрэг ямар ч нотолгоо, баримт байхгүйг л өөрт нь ойлгуулчихаж байгаа хэрэг.

Үнэхээр ч Нелидов улам хатуурхаж, энэ удаа ч ямар нэг мэдүүлэг өгсөнгүй.

Шөнө нь түүнийг Молчанов руу аваачив.

Цаадахь нь Нелидов руу шазруун харж,

-Та яагаад тоглоом тохуу хийгээд мэдүүлэг өгөхгүй байна? гэж ууртай асуув.

-Та болгоогоорой, би худлаа хэлж сураагүй, тэгэх тусмаа ямар ч гэм буруугүй хүмүүсийг, оюутнуудаа, хамт ажилладаг нөхдөө гүжирдэх зүрх даан ч алга...

Молчанов үгийг нь тасдав.

-Гэм буруугүй хүмүүс гэж та хэнийг хэлж байна? Бусад яллагда-гийн мэдүүлж байгаа, үнэнд яг нийцээд байгаа зүйлийг та нотлох ёстой. Та л ганцаараа үгүйсгэж байна. Эсвэл бусад нь бүгд худлаа яриад, ганц та л үнэнийг хэлээд байгаа юм уу?

-Тийм ээ, би үнэнийг л ярьж байгаа. Та надаас ганц худал үг олж сонсохгүй.

Молчановын дуу чангарав.

-Нелидов, танд сүүлчийн удаа сануулья: Битгий тохуу хийгээд бай! Бид таны язгууртны аагийг оргүй болгож чадна шүү. Бид танай бүхэл бүтэн ангийг, танай төрийг, танай армийг хүчирсэн гэдгийг та битгий мартаарай, тэгэхээр ганц таныг мэдээж маш түргэн дөнгөнө.

Нелидов гэнэтхэн Молчановын ширээ рүү огцом алхав. Үнэхээр санамсаргүй юм болж Молчанов хүртэл гэдэсхийв.

Нелидов түүний ширээг тулан, нүд рүү нь эгцлэн харав:

-Би танаас айхгүй, үүнийг тогтоож аваарай. Намайг явал яацгаа, би л ямар ч байсан өөрийгөө бас огт гэм буруугүй хүмүүсийг хэзээ ч гүжирдэж гүтгэхгүй, үүнийг тогтоож аваарай, хэзээ ч тийм юм хийхгүй.

Зургадугаар сарын эхээр ТХ-ны Бүгд хурал дээр Сталин ЗСБНХУ-ын Үндсэн хуулийн төслийн тухай илтгэл тавив. Бүгд хурал төслийг сайшааж, түүнийг хэлэлцүүлэх Зөвлөлүүдийн Бүх холбоотын их хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргалаа.

Гэхдээ Бүгд хурлаар хэлэлцсэн гол асуудал нь намын бичиг баримтыг солих тухай асуудал байжээ.

Энэ бол түүний санаа. Энэ санааны гол утга юу вэ? Өнгөнөөс нь харвал зөвхөн техник ажил шиг байгаа нь гол утга. Намын батлах солих нь үнэн хэрэгтээ бол коммунист нэг бүрийг толгой дараалан маш чанд, маш нягт шалгана гэсэн үг.

Энэ утгаар авч үзвэл намын доторхи цэвэрлэгээ зорилго хангахгүй байгаа юм. Коммунист индэр дээр гараад өөрийнхөө тухай ярина, араас нь найз нь магтана, дайсан нь муулна, аль нь үнэн болох нь бүү мэд, намд байсан хугацаа л гол үүрэг гүйцэтгэнэ. “1917 оны дөрөвдүгээр сараас намын гишүүн” бол ямар ч нүгэлгүй хүн, хэрэв “1905 оноос намын гишүүн” гэвэл ердөө гэгээнтэн гэсэн үг. Ийм цэвэрлэгээ коммунистын жинхэнэ нүүр царайг илчилж чадахгүй байгаа билээ.

Намын бичиг баримтыг шалгах бол өөр хэрэг, түүний явцад коммунистын намтрыг бүрэн судлана, амьдралынх нь өдөр болго-ноор судлана, төрөл садны, найз нөхдийн, албан ажлын хэлхээ холбоог судлана, хэлж ярьж байсан зүйл, ДЯАК-т буй хавгаст хэрэг сэлтийг судлана.

Намын бичиг баримтыг солих нь боловсон хүчний хувьсгалын таатай үндэс болно. Коммунист бүр байнгын, сулрашгүй, сонор соргог хяналтанд байгаагаа мэдэрч байх ёстой.

Өнөөгийн нөхцөлд большевик нэг бүрийн эрхэм чанар бол дайсан хичнээн танигдамгүй багтай байлаа ч гэсэн түүнийг таньж чаддаг байх явдал гэдгийг бүх намд өөрөө биечлэн нийтийн өмнө сануулах хэрэгтэй болсон. Бас коммунист гэдэг нэрийн итгэлийг даагаагүй намын гишүүдэд намын байгууллага нь гишүүний батлах олгохгүй байж болохыг сануулахад хүрсэн.

Зургадугаар сар тун завгүй болж таарлаа. Тэрээр нисэгчидтэй уулзсан, Губкинтэй Уралын газрын тосны талаар ярилцсан, Каганович Оржоникизе хоёртой хамт Москва-Волгийн сувгийн нэг хэсэгтэй танилцсан, Суваг барих ажил ирэх онд дуусах ёстой, Москва хот таван тэнгисийн -Цагаан далай, Балт, Каспий, Азов, Хар далайн- боомт болно. Энэ суваг бол Москваг сэргээн босгох ерөнхий төлөвлөгөөний, түүний төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг.

Тэрээр зургадугаар сарын 8-нд Горкид хэвтэж байгаа Горькийг эргэжээ. Молотов, Ворошилов хоёртой цуг. Тэгээд арав хоногийн дараа, зургадугаар сарын 18-нд Горький нас барсан. Бүх ард түмний гашуудал зарлаж, талийгаачийг зургадугаар сарын 20-нд Улаан талбай дээр оршуулжээ.

Мань хүн Горький нас барсанд харамссан уу? Аливаа хүн заяагдсан цагтаа нас эцэслэнэ. Уран бүтээлчийн хувьд Горький дуусах нь тэр. “Егор Булычев” түүний уран бүтээлийн, м э д

э э ж, оргил нь. “Клим Самгин”-ы тухайд гэвэл тэр балай нуршсан зүйлийг Тэрээр одоо хүртэл уншиж чадаагүй. Ер нь ч туульс бичих бол Горький хийх ажил биш, туульсын бүтээлд түүхийн томоохон зүтгэлтний дүр хэрэгтэй, гэтэл “Клим Самгин”-д ямархан зүтгэлтний дүр байгаа билээ дээ?! “Бага нас”, “Хүмүүсийн дунд”, “Миний их сургуулиуд” энэ тэр бол Горькийн өөрийнх нь зохиол, сайн зохиол, тэнд жинхэнэ амьдралыг харуулсан, “Клим Самгин”-ых шиг зохиомол амьдрал биш. түүний тухай бичих гээд байх шиг байсан, гэхдээ “материал цуглуулсаар” байгаад таарсан, яагаад ч юм бэ, дэндүү удаан цуглуулж дээ. Харин нөгөө “Бүсгүй, үхэл хоёр”-ын тухайд мань хүн, “Энэ ч Гётегийн “Фауст”-аас хүчтэй эд” хэмээсэн нь мэдээж, зулгуйдсан хэрэг. Угаасаа жишихийн аргагүй өөр зүйл шүү дээ. Гэтэл мань хүн тэгж хэлээд зогсоогүй, мань хүн тэгж бичсэн, түүхэнд үлдээсэн, Горькийтэй харилцах харьцаагаа хойч үеийнхний шүүлтээс дээгүүр тавьж буйгаа түүнд харуулж байгаа нь тэр. Утга зохиол судлаачид тэр үнэлэлтийг зуун жилийн дараа юу гэж тайлах нь түүнд падгүй, харин Горький одоо түүний бодлогыг улс орны дотоодод болон даян дэлхийд хэрхэн тайлбарлаж байгаа нь түүнд чухал.

Горький хийх юмаа хийсэн-сэхээтнийг нэгтгэсэн. Ард түмнийг захирахын тулд сэхээтнийг нь устгах буюу худалдаж авах хэрэгтэй. Үгүй ээ, нэг хэсгийг нь устгаж, нөгөө хэсгийг нь худалдан авч айлган барьж байх хэрэгтэй гэж хэлэх нь арай зөв. Горький “Хэрвээ дайсан бууж өгөхгүй байвал түүнийг устгадаг юм” гэж хэлснээрээ тэр үүргээ биелүүлсэн юм. Энэ бол боловсон хүчний хувьсгалд сэхээтний нэрийн өмнөөс түүний оруулсан жинтэй хувь нэмэр. Гэхдээ зохиолчид юу ярьж буйгаа тэр болгон гүйцэд ухамсарладаггүй, гоё хэллэг, цэцэн үг хөөцөлдөн, хэлэх юмныхаа санааг будлиулах нь элбэг, бас яг бодож байгаагаасаа арай өөр юм ярих нь ч бий. Каменев, Пятаков, Бухарин мэтийн шаарнуудын дотор Горькийн хувийн олон найз бий, тэднийг шүүн таслах ажиллагааны үеэр мань эр ямар зан гаргах байсныг бүү мэд.

Тийм учраас зөв нас барсан, цагаа олж нас барсан. Нас нөгчсөн ч боловсон хүчний хувьсгалыг сайшаасан: “Хэрвээ дайсан бууж өгөхгүй байвал түүнийг устгадаг юм”. Ийм уриа үлдээлээ, сайхан уриа.

Тэрээр бүхэлдээ, засагт үнэнч байсан. Гэхдээ заримдаа тангарах гэж үзнэ, ноднин Панферовоор өгүүлэл бичүүлж номхруулсан, манайд халдашгүй дархан хүн байхгүй гэдгийг харуулахад хүрсэн. Нөхөр Горький өөрөө урлаг, утга зохиол санал бодлоо чөлөөтэй солилцох орчинд л хөгжих ёстой гэж номлодог шүү дээ. Тэгээд л Панферов өөрийнхөө бодлыг чөлөөтэй хэлсэн нь тэр.

Горький бүгдийг ойлгосон. Тэгээд адармаалахаа больсон. Шостакович болон хэлбэрдэгч хөгжмийн зохиолчдыг зад авсан-мань хүн дуугараагүй, уран барилгач Мельников түүний хамсаатан хэлбэрдэгчдийг зад авсан-бас дуугараагүй, зураач-нялагчдыг, түүний дотор Каменевын дүүг зад авсан-бас дуугараагүй. За, эд нар ч яахав, шууд утга зохиол биш, зэрэгцээ салбарууд. Харин гурав-дугаар сард Булгаковыг тас ороолгосон, энэ бол утга зохиол, Горький бол энд магнай хүн, гэтэл бас ганц үг ганхийгээгүй...

Тэглээ ч гэсэн эцэстээ хүртэл найдвартай хүн биш. Арван долоон он үүнийг батласан, Октябрийн хувьсгалд хэрхэн хандсан нь үүнийг давхар нотлосон. Тэгэхээр боловсон хүчний хувьсгалаар ямар ааш гаргах байсныг бүү мэд. Нөгөө дэлхийн олон нийтийн санаа бодол гэгчийн өмнө нэр нүүрээ алдахгүй гэх ч байсан юм бил үү.

Тийм учраас зөв нас барсан, цагаа олж нас барсан. түүний дурсгалыг мөнхжүүлэх хэрэгтэй, түүний нэр ард түмний сэтгэл зүрхэнд хоногшин үлдэх ёстой. “Хэрвээ дайсан бууж өгөхгүй байвал түүнийг устгадаг юм”. Тэрээр сэхээтнүүдэд нам, зөвлөлт төрд зүтгэхийн үлгэр дууриал, өнөөгийн удирдлагад үнэнч байхын үлгэр дууриал болж үлдэх ёстой.

Харин хэн ч нас барсныг эс харгалзан амьдрал үргэлжилж байна. Үргэлжлэх ч ёстой. түүний санаачлагаар “Дээд сургуулиудын ажлын тухай”, “Үр хөндөхийг хориглох тухай”, “Хүүхдийн хүмүү-жил дэх завхруулгын тухай” зэрэг маш чухал шийдвэрүүд гарлаа.

Шинэ төр улсыг бат бэх суурин дээр байгуулах хэрэгтэй. Хувьсгал хуучин дэг журмыг эвдэнэ, гэхдээ шинэ дэг журмыг хувьсгал өөрөө тогтоох ёстой. Хөдөлбөргүй, бат бэх дэг журам. Үүний тулд амьдрал, ахуйн үе улиран шалгагдсан, зөв зүйтэй нь нотлогдсон хэлбэрийг хувьсгал заавал ашиглах ёстой.

Долдугаар сарын 9-ний орой Тбилисээс Берия утасдав.

-Нөхөр Сталин! Гүрж, Азербайжан, Арменд хувьсгалын эсэргүү алан хядах байгууллагыг илрүүлсэн тухай мэдээллийг өнөөдөр хязгаарын намын хорооны товчоо хэлэлцсэн юм. Сонор сэрэмж ноцтой сулруулсан учраас Армений ТХ-ны нарийн бичгийн дарга Ханжянд дутагдлыг нь зааж тулгасан. Ханжян тэр шүүмжлэлийг эрс эсэргүүцсэн. Өнөө орой, нэг цагийн өмнө тэр над дээр ирж, шижээргүй загнан, намайг намын ахмад боловсон хүчнийг хөнөөж байна, намын түүхийг гуйвуулж байна гэж гүжирдсэн. Ер нь жигтэйхэн дэвэрсэн байдалтай байсан, намайг ална гэж зангаад, золтой л алчихсангүй, би биеэ хамгаалахын тулд амжиж өрсөөд түүнийг буудчихлаа.

Сталин дуугарсангүй.

-Нөхөр Сталин, та намайг сонсож байна уу?

-Сонсож байна гэж Сталин аяархан хариулснаа дахиад чимээгүй болчихов.

Берия ч бас дуугарч чаддаггүй.

Тэгж тэгж байснаа Сталин,

-Аппаратынхаа ажилтнуудад ямар тайлбар хийх гэж байна? гэж асуув.

-Амиа хорлосон.

-Тэгвэл олон нийтэд юу гэж тайлбарлах вэ?

-Яг адилхан тэгж хэлнэ гэж бодож байна.

-Хэдтэй байсан юм бэ?

-Гучин тавтай.

Сталин чимээгүй азснаа,

-Маргааш ТХ-ны удирдах ажилтан танай руу ниснэ гэж хэлэв.

Тэгээд утсаа тавьчихжээ.

Бослоо.

Өрөөн дундуураа хэд алхлаа.

Хязгаарын намын хорооны нарийн бичгийн дарга Холбооны улсын намын ТХ-ны нэгдүгээр нарийн бичгийн даргыг өрөөндөө буудаад алчихаж.

Намын дотор гарч буй анхны тийм тохиолдол.

Мэдээж, Берияд өөрийгөө хамгаалсан юм байхгүй л дээ. Ханжян түүнийг алах гээгүй, тэгэх хүн биш, муу хүн, гэхдээ хязгаарын намын хорооны нарийн бичгийн даргыг алж чадахгүй, ямар ял ирэхийг ойлгоно.

Берия зүгээр л буудаад алчихсан. Гэхдээ түүнд шудрагаар хэлж байна. Ханжян өөрийгөө алчихсан гээд гэрч нар цуглуулж протокол биччихээд, худлаа хэлж чадах шүү дээ. Юуг ч чадна. Үгүй ээ, түүнд худлаа хэлж чадсангүй. Гарцаагүй эрүүгийн хэрэгтэн, гэхдээ үнэнч хэрэгтэн.

Ер нь Берияд хэцүү байсан л даа. Өвөр Кавказынхан түүнийг хүлээн зөвшөөрөхийг хүсээгүй. 1931 онд Улс төрийн нэгдсэн газрын төлөөлөгчөөс Гүржийн ТХ-ны нэгдүгээр дарга, тэгснээ 1932 онд Өвөр Кавказын хязгаарын намын хорооны нэгдүгээр дарга болчихсон, БХК(б)Н-ын ТХ-ны гишүүн ч биш, ердийн нэгэн чекист. Гэтэл Гүржид намын мундаг мундаг ажилтан, ТХ-ны гишүүд бий шүү дээ. Жишээлбэл, 1903 оны гишүүн Мамия Орахелашвили, 1910 оны гишүүн Картвелишвили, тэд нар өөрсдийгөө Өвөр Кавказын намын байгууллагыг үүсгэн байгуулагчид гэж үздэг, гэтэл Онцгой коми-ссын мөрдөгч, хэн ч мэдэхгүй Берия гэж нэг юм гараад ирсэн хэрэг Тэрээр 31 онд Цхалтубод амарч байхдаа Бериятай ойртож танилцсан билээ.

Тэгэхэд Берия ЗСБНХУ-ын Улс төрийн нэгдсэн газрын Өвөр Кавказ дахь төлөөлөгчийн хувьд түүнийг хамгаалах ажлыг биечлэн хариуцахдаа 250 чекистээр гурван давхар бүслэсэн хамгаалалт хийж, өөрөө бүтэн хагас сарын турш түүнээс холдоогүй.

Бүтэн хагас сарын хугацаанд хүнийг таньж болно. Тэрээр түүнийг сайн судласан. Берия Өвөр Кавказын бүх удирдагчийн тухай түүнд дэлгэрэнгүй мэдээлж, хүн нэг бүрийн талаар тагнуулын тодорхой мэдээнүүдийг танилцуулсан. Тэрээр ӨӨРИЙНХ нь тухай хэн юу ярьж, хэн юу бодож явдгийг мэдэж авсан. Тэдний тухай ӨӨРИЙНХ нь дотроо сэжиглэж явсан зүйл нотлогдсон болохоор Берия шудрагаар үнэн зөв мэдээлсэн. Тэд нар хувьсгалын өмнөх Кавказад түүний гүйцэтгэсэн жинхэнэ үүргийг тогтоож буйг “түүхийн засвар” хэмээн нэрлэж бүгд эсэргүүцдэг. Тэд нар л “гэрч” юм гэнэ, тэд нар л “шууд оролцогчид” юм гэнэ. Бүх “ахмад большевикуудаас” хамгийн тэвчишгүй нь тэд нар, өөрсдийгөө түүнтэй адилтгана,

өөрсдийгөө ТҮҮН шиг “Өвөр Кавказын хувьсгалт тэмцэлд оролцогсод” гэж сэхүүн зан гаргана. Берия тэднийг зөв ойлгож, яг таньж чаджээ.

Берия өөрийнхөө тухай ч ярьсан. Дэлгэрэнгүй ярьсан, чухам хэр шудрага ярьсныг хэн ч мэдэхгүй. Сухумийн ойролцоо Мерхеули гацаанд төрсөн, Бакуд техникийн дунд сургуульд суралцсан, 1917 оны гуравдугаар сард намд элсэж, нууц байдалд ажиллаж байсан. Намын байгууллагын даалгавраар мусаватын нууц тагнуулын албатай холбоо тогтоосон.

Берия энэ тухай онцгой цохож, энэ шийдвэрийг гаргасан Бакугийн намын хорооны бүх гишүүнийг толгой дараалан нэрлэж, тийм даалгавар өгснийг нотлосон тэдний гарын үсэг бүхий бичиг хүртэл үзүүлсэн.

Тэрээр тэр цаасыг нь харалгүй, цааш нь болгосон. Тэр цаас яг ёсоороо байгааг ойлголгүй яахав, тийм биш бол Берия үзүүлэхгүй. Харин энэ хүн мусаватын тагнуулын албатай холбоотой байсан юм чинь өөрийнх нь гарт орлоо гэсэн үг. Өдөөн хатгагч гэдгээр хүнийг буудан алахын цагт нууц тагнуулын албанд намын даалгавраар очсон уу, сайн дураар очсон уу гэдгээ батлаж байх хугацаа түүнд олдохгүй.

Ямар ч атугай энэ хүн зүтгэж чадах хүн, зүтгэх ч болно, бас я а ж зүтгэхээ мэдэх хүн байна. мань хүн Цхалтубод байхдаа л Өвөр Кавказын ихэмсэг явцуурагчдын учрыг олох хүн чухамхүү Берия мөн гэж шийджээ. Харин үүнийг хэрэгжүүлэхийн тулд зохих эрх мэдэлтэй байх ёстой.

Улс төрийн нэгдсэн газрын удирдлагын суудал дээрээс мань эр тэднийг дийлэхгүй. Өвөр Кавказад боловсон хүчний хувьсгал хийхийн тулд тэр Өвөр Кавказын намын удирдагч байх ёстой. Гагцхүү тэр өндөрлөгт байснаар хэрэггүй хүнээс салж, хэрэгтэйгээ тавин, хүмүүсийг сольж хольж чадна.

түүнийг Москвад буцаж ирсний яг дараа, 1931 оны намар Гүрж, Азербайжан, Арменаас Өвөр Кавказын хязгаарын намын хорооны удирдлагад байдаг бүх хүн ТХ-нд дуудагджээ. Тэр зөвлөл-гөөнөөр юу хэлэлцэх гэж буйг зарлаагүй. мань хүн эдийн засаг, үндэсний ажил явдал, бас бус зүйлийн тухай цаг орчим тогтуун сайхан ярьсан, бүх юмыг аятай сайхнаар хийхийг бодож л дээ.

Дуусаад босохдоо,

-Хязгаарын намын хороог бид нар ингэж бүрэлдүүлвэл ямар вэ? Нэгдүгээр нарийн бичгийн даргаар Лаврентий Картвелишвили, хоёрдугаараар Лаврентий Берия? гэж хэлжээ.

Тэрээр цаадуул нь энэ саналыг яаж хүлээж авч буйг тодхон харав: Нүд нь бүлтийгээд, хэл нь татчихсан юм шиг болцгоосон, тэр битгий хэл, мань хүн аль хэдийн босчихоод байхад тэд нар босох ухаанаа олохгүй байжээ.

Зөвхөн Картвелишвили өөрөө л,

-Би энэ муу гайхалтай цуг ажиллахгүй гэж эрсхэн хариулсан.

Лаврентьев гэдэг цолтой Лаврентий Картвелишвили ӨӨРТ нь ингэж хариулж зүрхэлсэн юм даа. Ингэхэд, 31 он ч тэд нар яггүй зоргоороо байсан үе дээ.

Бүгд жуумалзацгаасан. Орахелашвили, Мусабеков, Буниат-Заде энэ тэр гээд цөмөөрөө. Тэр ч байтугай, намын хорооны жирийн ажилтан, зохион байгуулах хэлтсийн дарга Снегов хүртэл жуумалзсан. Та нарын энэ жуумалзсаныг мартана байгаа даа, гайгүй байлгүй.

Ганц Ханжян л жуумалзаагүй. Таг чиг хүрлийгээд сууж байсан, жуумалзах мөч биш гэдгийг ойлгож байж. Зальтай толгой. Зальтай гэдэг чинь аюултай хүн гэсэн үг.

Тэгээд мань хүн,

-За, яахав, харьцгааж бай. Асуудлыг ажлын журмаар шийдье гэж хэлсэн.

Тэгээд өөрийнхөөрөө болгосон нь мэдээж. Лаврентий Картвели-швилийг (Тэрээр зөвхөн Лаврентьев гэдэг нэрээ хэрэглэж байхыг түүнд тушаасан) Сибирыг намын ажилд явуулаад, Мамия Орахе-лашвилийг нэгдүгээр дарга, Берияг хоёрдугаар дарга болгожээ.

Хэдэн сарын дараа Орахелашвилийг Москвад шилжүүлэн авчирч Марк-Энгельс-Лениний институтын орлогч захирлаар томилжээ.

Берия Өвөр Кавказын хязгаарын намын хорооны нэгдүгээр дарга болов.

Энэ таван жил арай хүрэхгүй хугацаанд өөрийгөө сайн харууллаа. Районы намын хорооны бүх дарга нарыг сольсон, аппаратын ажилтнуудыг бүгдийг нь шигшиж эргүүлсэн, Өвөр Кавказын хэмжээнд боловсон хүчний хувьсгалыг амжилттай хэрэгжүүлж байна, Ягода, Ежов энэ тэрийн оролцоогүй өөрөө хэрэгжүүлж байна, ӨӨРТЭЙ нь шууд харьцдаг хүн. Ягода, Ежов хоёр тэнд хэрэггүй. Берия ТЭР хоёр л Кавказын байдлыг илүү сайн мэднэ.

Азербайжанд өөрийн хүнтэй болчихсон. Тэр нь Багиров. Багиров Мусабеков болон бусад сэтгэл дундуур хүмүүсийн учрыг олсон. Сэтгэл дундуур байдал, мэдээж, үлдсэн, гэхдээ тэр байдал тийм хүмүүсийнхээ хамт удахгүй алга болно.

Харин Армени бол Бериягийн хувьд хатуу бүлх. Ханжян бол хоолойд тээглэсэн яс. Ханжян Берияг хүлээн зөвшөөрөөгүй, яаж зөвшөөрч чадахав. Яагаад Ханжян өөрөө биш, Берия байдаг билээ? Өөрөө 1930 оноос Армений намын ТХ-ны нэгдүгээр дарга байгаа юм чинь. Өөрөө бол жинхэнэ намын ажилтан, Берия бол до яамных, томилолтын хүн, яах гэж томилогдсон нь нийтэд тодорхой. Тийм учраас Ханжян армянчуудаа тас өмөөрнө, тэр ч байтугай нөгөө гэгээрлийн ардын комиссар Степаняныг хүртэл хамгаалсан. хэн гэдэг билээ дээ? Нерсикийг. Нерсик Степаняныг. Тэр муу нохойн гөлөг Бериягийн “Өвөр Кавказын большевик байгууллагуудын түүхийн асуудалд” гэдэг номыг шүүмжилсэн байхад түүнийг хамгаалсан.

Берия энэ номыг түүний даалгавраар бичсэн. Энэ ном бол Авель Енукизегийн зохиомол хуурамч зүйлийн няцаалт. Уг номонд бүхэлд нь большевик намд, түүний дотор Өвөр Кавказад түүний гүйцэтгэсэн үүргийг зөв тусгасан юм. Берия юуных нь зохиолч байхав, номонд дутагдал бий л дээ. Бас өөрөө бичээгүй гэх ч хов жив бий. Тэр ямар хамаа байна?

Хэрэгтэй л ном. Энэ б ү г д э д ойлгомжтой. Гэтэл Степанян тэр номыг шоолж, олон гуйвуулгатай хуурамч шинжлэх ухааны барилаар бичигдсэн гэх маягаар шүүм-жилсэн. Степанян хэний эсрэг ингэж байна? Бериягийн эсрэг үү? Үгүй ээ, ӨӨРИЙНХ нь эсрэг, намын түүхэнд түүний жинхэнэ үүргийг сэргээн тогтоохын эсрэг тэгж байхгүй юу. Берия түүнийг ардын дайсан гэж буудан алахыг шаардсан. Ханжян тэгүүлээгүй. Степаняныг шүүсэн, гэхдээ буудан алахыг зөвшөөрөөгүй. хэнд ч гар хүргэхгүй байсан юм. Зальтай толгой. Хоёр нүүрт.

Гучин хоёр бил үү, гучин гурван онд Сочид байхад нь ТҮҮН дээр хэсэг армян ирснийг Тэрээр нэхэн санав.

Идэж ууж сууцгаасан. Дараа нь сэхээвч рүү гарцгаасан, нар төөнөж байсан цаг. Ханжян түүний хөл рүү харснаа,

-Та савхин гуталтай халууцахгүй байна уу? гэж асуусан.

Заяагүй золиг! Энэ чинь түүний бүхэнд ижил дасал болсон дүр шүү дээ. Жолоодогчийн дүр. Ард түмэн түүнийг ийм л дүрээр мэднэ, улс орон, даян дэлхий энэ л дүрээр мэднэ. Эелдэгхэн, санаа тавьж инээмсэглэн асуусан. Дооглож асуусныгаа тэр инээм-сэглэлээрээ түүнээс нууна гэж бодсон. Увайгүй шаар!

-Үгүй ээ! гэж мань хүн Ханжянд хариулсан. -Халууцахгүй байна. Харин шүд рүү дэлсэх, хоншоор руу нулихад амар байдаг юм.

Ханжян эелдэгхэн инээмсэглэсэн. Гэхдээ яг ойлгосон. Тэгээд, мэдээжийн хэрэг, улам том дайсан болсон.

Хэдий тэгэвч холбооны улсын коммунист намын Төв Хорооны нэгдүгээр даргыг өрөөндөө буудаж ална гэдэг бол онцгой этгээд явдал.

Оржоникизе Кобакизег алгадсаныг дуулаад Ленин яаж бухимдаж байлаа даа. Оржоникизег бараг намаас хөөхийг шаардаж байсан. Гэтэл Кобакизе гэж юу юм бэ? Гүржийн коммунист намын ТХ-ны ердийн нэг гишүүн, зүгээр ч үгүй нугалааных...

Ханжян, гарцаагүй, увайгүй шаар! Тэглээ ч гэсэн ямар ч мөрд-лөггүй, ямар ч шүүхгүй өрөөндөө түүнийг буудаж алж болох уу?

Нөгөө талаас Берияг алдах уу?

Сталин Поскребышевг утасдаж Маленковыг өөр рүүгээ дуудахыг тушаав.

Маленков ирлээ.

Сталин түүн рүү ёозгүй харав.

Нэлээн удаан тэгж харлаа.

Сталин эсвэл нэг юманд сэтгэл гонсгор байгаа, эсвэл нэг ноцтой даалгавар өгөх гэж байгааг Маленков ойлгов.

Сталин Маленковыг суу ч гэсэнгүй, өрөөн дундуураа холхих зуур,

-Өнөөдөр Бериягийн өрөөнд Ханжян өөрийгөө бууджээ. Сонор сэрэмж алдсан гэж хатуу зэмлэснийг даасангүй. Маргааш өглөө нисэхээр онгоц захиалаад Тифлист оч. Бүх зүйлийг тайван өнгөрөөх талаас нь анхаараарай гэж хэлэв.

Тэгээд хэсэг чимээгүй болсноо ингэж нэмэв:

-Гол зүйл. Берия өнөөдөр надад утсаар ярьсан бүх юмаа цаасан

дээр буулгаж, гарын үсэг зурж, дугтуйлж, лацдаж, тамгалаад танаар надад ирүүлэг. Үүнийг түүнд уламжлаарай. Та буцаж ирээд тэр дугтуйг надад биечлэн өгөөрэй. Бериягийн бичих цаас хэний ч нэр дээр, миний болон бусад аливаа хүний нэр дээр хаяглагдах ёсгүй. Зүгээр баримтын тодорхойлолт, гарын үсэг хоёр л байх юм. Гүйцлээ! Ёсоор болго!

Хоёр хоногийн дараа Сталин Маленковын авчирсан дугтуйг нээв. Берия түүний тушаасан ёсоор бүх зүйлийг биечлэн хийж Ханжяныг ямар нөхцөл байдалд буудаж алснаа дэлгэрэнгүй бичиж ирүүлжээ. Хаяггүй захидал. Сталинтай утсаар ярьсныгаа хэлээгүй, ер нь түүний нэрийг дурдаагүй байв.

Сталин Бериягийн захидлыг хувийнхаа нууцын шүүгээнд хийлээ.

Түүнээс хойш бас хоёр өдрийн дараа Сталин Ежовтой цуг ДЯАК-ын удирдлага-Ягода, Агранов, Молчанов, Миронов нарыг хүлээж авав.

Байдлыг Молчанов танилцуулав.

Сталины сэтгэл ханасангүй.

-Үнэмшил муутай байна. Зөвхөн ам мэдүүлэг. Баримт хэрэгтэй, захидал, тэмдэглэл...

-Тийм баримт байхгүй гэж Молчанов хариулав.

-Баримт байхгүй хэмээн Сталин түүний үгийг давтав. -Тэгвэл юу байна? Яриа юу? хэнтэй ярьсан яриа вэ? Седовтой юу? Үнэмшилгүй байна. Троцкий өөрөө заалт, даалгавар өгөх ёстой. Гольцман Седовоос заалт авсан гэж зүтгэж байна. Гольцман худлаа хэлж байгаа юм биш үү? Тэр чинь Седовтой биш, Троцкийтэй уулзсан юм биш үү?

Мочанов зөрсөнгүй, тэгэхээр анхааралдаа авлаа гэсэн үг. Ягода, Агранов хоёр ч дуугарсангүй, бас анхааралдаа авлаа гэсэн үг.

Дараа нь мөрдлөгийн явцыг Миронов илтгэж, хэн ямар мэдүүлэг өгсөн, хэн өгөхгүй ялдагласаар байгааг танилцуулав.

Сталин гайхасхийн магнайгаа үрчийлгэв.

-Каменев хүлээхгүй байна ий? Нээрээ юү?

-Тийм, хүлээхгүй байгаа.

-Үнэхээр хүлээхгүй байна гэж үү? хэмээн Сталин хорсолтой асуув.

-Тийм.

-Өчнөөн хэрэг хийчихээд хүлээдэггүй ээ?

-Тийм.

-Амь насандаа харамсахгүй байна уу?

Миронов дал мөрөө хавчив.

-Бас хүүхдүүдийнхээ амь насанд харамсахгүй байна уу?

Миронов дуугарсангүй.

-Тэднийх хоёр хүүтэй. Үнэхээр томьгоо ч, багыгаа ч өрөвдөхгүй байна уу?

Миронов юу гэж хариулах ухаанаа олдоггүй...

-Та яагаад чимээгүй байна? Би танаас асууж байна?

-Харамсаж байгаа гэж би бодож байна

-А-аан, та тэгж бодож байгаа юм байж! гэж Сталин шазвалзав. -Тэгвэл Каменев, эсвэл Зиновьев, эсвэл өөр хэн нэгэн мэдүүлэг өгөхгүй байна гэж надад битгий ярь гээд бүгдээрэнг нь муухай харлаа. -Тэд нар юу ч хийлээ гэсэн, ямар ч арга хэрэглэлээ гэсэн түүхийн хүрдийг зогсоож чадахгүй гэж тэдэнд хэлээрэй. Тэд нар эсвэл турсагаа аврана, эсвэл үхнэ, яг ингэж уламжлаарай! Амь насаа авч үлдэе гэж байгаа бол мэдүүлэг өгцгөөг! Цаадуултайгаа ажилла, мэдүүлгээ зуугаад хэвлийгээрээ мөлхөөд иртэл нь жаахан ажилла!

хэн ч дуугарсангүй. Сталиныг ууртай байхад болгоомжгүй үг хэлсэн хүн баларч мэдэх билээ.

Сталин түр азснаа нам дуугаар тайван үргэлжлүүлэв.

-Зиновьев хэрвээ сайн дураараа шүүгдвэл, илшүүхээр шүү, тэгээд бүх буруугаа хүлээвэл түүний амийг хэлтрүүлнэ. Эс тэгвэл түүнийг цэргийн шүүхээр шүүнэ. Тэгээд буудан ална. Хуучин болон өнөөгийн түүний талынхныг бас буудан ална. Өөрийнх нь амь нас өөрт нь хэрэггүй юм гэхэд, намаг руу татаж оруулсан бусад хүмүүсийнхээ амь насыг бодог л дээ. түүнд үүнийг уламжлаарай.

Ягода, түүний туслахууд гарцгаалаа.

Сталин босч өрөөн дотуураа хэд алхав. Ежов бас өндийтөл Сталин түүнийг суу гэж дохив.

-Эд нар яг хэдэн хүнийг бодитойгоор шүүхэд өгч чадах бол?

-Арван зургаа.

-Тэдний чинь найм нь эрхбиш гайгүй зиндааных, бусад нь юу ч биш гээд Сталин тамшаалав.

-Бусад нь гүйцэтгэгчид гэж Ежов болгоомжтой өчив.

Сталин түүнийг сонсоогүй мэт үргэлжлүүлэв.

-Бараг дөрвөн зуугаад хүн авчирчихаад дөнгөж арван зургаах-ныг нугаллаа гэнэ ээ. Мөн ч сайн ажиллаж байна шүү, хэлэх үг алга.

Энэ зэмлэл Ягодад хамаарч буйг Ежов сайн ойлгож байв.

-Миронов, Молчанов хоёр сайн ажилтан, ялангуяа Миронов, гэхдээ тэд нар хэлбэрдэгчид, яль шаль юмаар ёсорхогчид, тэдэнд протокол л байвал бүх юм болох нь тэр! Яагаад тэр вэ? Протоко-лоор хаяагаа манах санаатай, ямар нэг юм болвол протоколоор хаацайлж, биендээ хир халдаахгүй гэж тэр. Гэтэл “ямар нэг юм болвол” гэж юу вэ? гэсэн асуулт гарч байна. Юуных нь “ямар нэг юмнаас” тэд айгаад байна вэ? Зөвлөлт засгийг унана гэж айгаа юу? Хэрвээ Зөвлөлт засаг унах юм бол ямар ч протокол тэдэнд тус болохгүй, хэн ч тийм цаасыг харахгүй, хамгийн түрүүнд тэднийг л дүүжлэнэ. Тэд юунаас айгаад байна аа? Намын удирдлага солигдо-хоос айж байна уу? Тэгэх вий гэж хаяагаа манаж байна уу? Харваас, чухамхүү тэгж л хаяагаа манаж байна. Тэд нар Ягодын хүмүүсийг ч хэлэх үү. Гэтэл Ягода шүүн таслах ажиллагааны бэлтгэлийг зориуд саатуулж байна. Гэхдээ удирдлага солигдохоос бо л г о о м ж и л ж буй бус, удирдлага солигдоно гэж г о р ь д о ж байна, удирдлага солигдоно гэж итгэж байна.

Сталин ширээ рүү очиж, Ягода, түүний туслахуудын сууж байсан сандлыг дотогшлуулав.

-Гэхдээ энэ шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэг, түүнд саад хийх хэрэггүй. Харин тэр нөхөр энэ ажиллагааныхаа явцад дараачийнхийг бэлтгэх ёстой. Энэ ажиллагаагаар зиновьевчуудыг дуусгах хэрэгтэй, дараачийнхаар нь троцкийчуудыг... Нэр усыг нь одоо хэлцгээг... Нэр, нэр, бас дахин нэр. Хичнээн мундаг хүний нэр гарна, төдийчинээ сайн. Ягодаас, түүний туслахуудаас, мөрдлөгийн бүх хэсгээс үүнийг шаардах хэрэгтэй. Та энэ аппаратын ажлыг тулж авч үзэж, яваандаа мөрдлөгийг гартаа авах нь зүйтэй гэж бодож байна. Ягода-найдваргүй хүн. Гэхдээ давтан хэлэхэд, энэ ажиллагааг, Зиновьев, Каменевыг шүүн таслах ажиллагааг тэр эцэст нь хүргэж гүйцээх ёстой.

Сталин өрөөнд дотуураа зугуухан алхалсаар.

Сталин түүнд одоо нэг чухал зүйл, магадгүй хамгийн гол зүйлээ хэлэх гэж буйг Ежов ойлгон мэдрээд тэвчээртэй хүлээнэв.

-Троцкийчууд бүгд цэргийн хүмүүс явсан улс. Тэднээс олон хүн армид үлдсэн. Дивиз командлагч Шмидт, жишээ нь, 23 онд сөрөг хүчний төлөө саналаа өгч байсан, хожим тэднээс холдсон гэлцдэг, гэвч хэн үүнд итгэхэв, Примаковын дотнын нөхөр. Шмидт, Примаков хоёрыг, мэдээж, нөхөр Якир хамгаална, гэхдээ нөхөр Якир мөрдлөг дуусахыг хүлээг. Дивиз командлагч Путна 23 онд бас сөрөг хүчний төлөө санал өгч байсан. Хуурамч хүн, Тухачевскийн шавь, дотнын нөхөр, тэдний хэлхээ холбоог шалгах нь зүйтэй, Путна найз, ивээгчийнхээ тухай-нөхөр Тухачевскийн тухай юу ярих нь сонин байна. Нөхөр Тухачевский Германы цэргийн хүрээнийхэнтэй ямар холбоотой нь онцгой сонин байх биз гэж бодож байна. Та материалаа аваад ирсэн үү?

-Тэгсэн гээд Ежов хавтсаа нээв.

-Ярь даа, таны тэнд юу байна?

Ежов хавтсан дотроосоо хамгийн дээд талын хуудсыг авлаа.

-Намтар нь байна.

-Хэрэггүй. түүний намтрыг би мэднэ. Германы тухайд юу байна?

Ежов өөр нэг хуудас гаргалаа.

-Юуны өмнө Германд олзлогдсонтой холбогдсон зүйл. Анх удаа 1915 оны хоёрдугаар сарын 19-нд Карпатад олзлогдож далайн эргийн Штральзунд хэмээх цэргийн олзлогсодын лагерьт хоригдсон. Оргосон. 3 долоо хоногийн дараа Швеци рүү явах завь хайж байгаад баригдсан. Мекленбургт Бадштуерийн шоронд орсон, тэндээсээ оргоод Данийн хил дээр баригдаж, Мюнстерийн орчим цэргийн лагерьт орсон, бас оргож Голландын хилээс 30 метрийн зайд баригдсан. Үүний дараа Кюстриний цайзад хоригдсон, газар доогуур нүх ухаж оргох гэж байгаад тэндээ баригдсан, тэгээд удаа дараа оргосон олзныхонд зориулсан Баварын Ингольштадт цайзанд хоригджээ. Тэндээсээ 1917 оны намрын сүүлээр оргосон, ийнхүү тавдахь удаагийнх нь орголт амжилттай болсон.

-Тэр Баварын цайзнаас чинь Оросын хил хүртэл хэр зайтай юм бол? гэж Сталин асуув.

-Мянга нэг зуун хорин километр.

-Тийм зайг яаж туулсан юм бол? Оросын офицер хүн?

-Тэр герман, франц хэл чөлөөтэй мэднэ.

-Дайсан улсын нутгаар тийм их зам туулахад хэл мэдэх төдий ч хангалтгүй дээ. хэн түүнд туслаа вэ?

-Энэ тухайд мэдээ байхгүй. Тэр Черновецкий гэдэг офицертэй хоюулаа оргосон юм. Гэтэл түүнийг гурав хоногийн дараа барьсан, харин Тухачевский баригдаагүй.

-Нэг нь баригдаж, нөгөө нь явчихаж. Сонин л юм байна. Мөрдөж мөшгөөд нэгийг нь бариад

авч, нөгөөг нь барьж авалгүй, мянган километр чөлөөтэй явуулчихаж. Сонин, их сонин байна. Цааш нь!

Ежов өөр нэг хуудас авав.

-Одоо албан ёсоор очиж байсан тухайд. Тухачевский Улаан Армийн дээд командлалаас Рейхсверийн дэргэд томилогдсон холбоо барих офицерийн хувьд анх 1923 онд Германд очсон. Герман-Зөвлөлтийн Рапаллийн гэрээний дагуу зөвлөлт-германы цэргийн яриа хэлэлцээ, хэлэлцээрүүдийг бэлтгэх ажилд оролцсон, хожим цэргийн хэлэлцээр байгуулагдсаны дараа хянан шалгах ажилд оролцсон, түүнээс хойш 1926-32 оны хооронд цэргийн салбарын хамтын ажиллагааны асуудлаар хоёр удаа очсон. Энэ яриа хэлэлцээ, эдгээр хэлэлцээр манай нутаг дэвсгэр дээрх, тодорхой нэрлэвэл, Липецк, Казань, Харьков хотууд дахь германы цэргийн объектуудтай хамаатай байсан учраас Тухачевскийн г а р ы н ү с э г т э й баримт бичиг германуудаас хойш тэнд үлдсэн байх нь дамжиггүй. Тухачевский энэ оны хоёрдугаар сард Английн хаан Ү Георгийн оршуулгат оролцоод буцахдаа Берлинээр сүүлчийн удаа дайрч өнгөрсөн.

-Цэргийн дээд удирдлагынхнаас Германд очсон өөр хэн хэн байна?

-Якир, Уборевич, Эйдеман, Тимошенко нар Германд ерөнхий штабын академид суралцсан.

Тэгээд гэмшингүй байдалтай,

-Бусад зарим хүн суралцаж байсан, очиж байсан гэв.

Нэрсийг бэлтгээгүй учир гэмшингүй царайлжээ.

Сталин үүнийг ойлгоод хатуу үүрэг өгөв:

-Германтай холбоотой цэргийн бүх хүний жагсаалт гаргаарай. Тэд нар бүгдээрээ германы тагнуул байх албагүй нь мэдээж. Жишээлбэл, нөхөр Тимошенко байна, түүнийг ном сургахаар явуулсан, тэр ч суралцаж байгаад ирсэн. Харин х э р з э р э г суралцсаныг бид харах болно. Гэхдээ цэргийнхээ албанд сайн зүтгэж байгаа шүү. Ард түмнээс гаралтай энгийн хүн, харин Якир, Уборевич, Эйдеман бас бус хүнийг нягт шалгах хэрэгтэй.

Сталин чимээгүй явж цонх руу очив. Цаг нь болсон уу, арай болоогүй юу? Бүх юм Ежовын гарт байх ёстой, үүнийг Ягодад итгэмжилж болохгүй. Ягода с а н у у л ч и х а ж мэднэ. Гэхдээ одоо Ягодаг Ежовоор солих эртдэнэ. Тэгсэн ч одоо эхлэх хэрэгтэй, Ежов амаа мэдэж ярьдаг хүн юм чинь.

Сталин цонхноос холдож, өөрийнхөө сандал дээр ирж суугаад Ежов руу тугалган харцаар харав.

-Нөхөр Тухачевский аман дээрээ бол Германы атаат дайсан. Ачир дээрээ бол германы генералуудын хүрээнд олон найзтай гэж би бодож байна. түүний намтар үүнийг тодорхой

өгүүлж байна. Нөгөөтэйгүүр манай цэргийнхэн ч, германы цэргийнхэн ч аль аль нь намын удирдлагаас хагацахыг хүсч байна. Германы тагнуулын алба цэргийнхний хэлхээ холбооны тухай мэдээлэлтэй байгаа гэж бодож байна. Бидэнд тийм мэдээлэл алга, харамсалтай нь германы тагнуулын алба манайхаас дээр ажиллах юм. Тэр мэдээллүүдээ бидэнтэй хуваалцвал германы тагнуулын албаны эрх ашигт хэр нийцэхийг би мэдэхгүй байна. Гэхдээ тэр мэдээллийг олж авах гэж оролдох хэрэгтэй. Биелүүлэх боломжтой зорилт гэж бодож байна. Харин үүнийг биелүүлэх ажилд Зиновьев, Каменев нарыг шүүн таслах ажиллагааны дараа орох хэрэгтэй.

Тэгээд бодосхийснээ,

-Ягода бол найдваргүй хүн гэж түрүүн хэлснээ давтан өгүүлэв.

Горькийн сурганы дээдийн химийн лабораторид хийсэн гэх бөмбөгтэй холбогдсон хувилбар хэрэггүй болжээ. Төмөр бөмбөлөг-гүүдийг шүүх хурал дээр эд мөрийн нотлох баримт болгож гаргаж тавьсангүй. Горький хотод Дьяковын зохиомлоор бүрдүүлсэн баримт бичгийг хэрэгт хавсаргаж, яллагдагсад алан хядах үйлдэл бэлтгэж байсны нэг гэрч болгон шүүх хурал дээр ашиглажээ.

Гэхдээ энэ бол улс орныг тэр аяар нь хамарсан аврага том хуйвалдаан байсныг нотлоно гэхэд даанч хариугүй баримт. Үүнийг зөвхөн Шарок ч биш, ер нь бүгдээрээ ойлгож байжээ.

Хуучин сөрөг хүчнийхнийг шантраах оролдлого үр дүнгээ өгсөн-гүй. Шорон, цөллөгнөөс авчирсан дөрвөн зуун хүнээс дөнгөж хоёр нь хэрэгтэй мэдүүлэг өгчээ. Нэг нь Троцкийн хувийн хамгаалалтын албаны дарга байсан Дрейцер, нөгөө нь Гадаад хэргийн Ардын Комиссариатын хариуцлагатай ажилтан Гольцман. Энэ хоёр дэндүү цөөднө. ЗСБНХУ-ын нутагт байгаа алан хядах төвийг Троцкий хилийн чанадаас удирдаж байсныг нотлохын тулд Гитлерийг засгийн эрхэнд гарахын өмнө Москвад ирсэн германы дөрвөн коммунистыг золиосонд гаргахдаа хүрчээ. Германы коммунист намын төв хэвлэл “Роте Фане” сонины ажилтан байсан Фриц Давид, Германд зөвлөлтийн сурвалжлагч хийж байсан Конон Берман-Юрин, мэс засалч Натан Лурье, эрдэмтэн Мойсей Лурье дөрөв. Тэд коммунистынхаа үүргийг биелүүлж, хэрэгтэй мэдүүлэг өгөх ёстой болжээ. Мэдээжийн хэрэг, хариуд нь амь насыг нь даана хэмээж.

Мөрдлөгийн хэсгүүд ийм хүчээр гол долоон яллагдагч руугаа дайрч дээ. Хуучин зинovieвчууд нь Зиновьев, Каменев, Бакаев, Евдокимов дөрөв, хуучин троцкийчууд нь Смирнов, Мрачковский, Тер-Ваганян гурав.

Эднийг мөрдөх ажлыг Сталин биечлэн хянаж чиглүүлж байгааг Шарок Вутковский, Молчанов хоёрын санаандгүй цухуйлгасан үгнээс хар авчээ.

Хуучин троцкийчуудын хэцүү нь юу вэ гэхээр, тэд нар, жишээ нь, Иван Никитич Смирнов шиг 1933 оны нэгдүгээр сарын 1-нээс шоронд ял эдлэж байсан гэдгээр ямар ч хэрэгт холбогдолгүйгээ нотлоцгоож байгаа юм. Тэд алан хядах үйл ажиллагааг шоронгоос яаж удирдах юм бэ?

Гэвч Сталин үүнийг хэрэгсэхийг хүссэнгүй. Тэрээр,

-Смирновыг Мрачковскийтэй ханинд нь мөрд гэж тушаажээ.

Сталин яагаад чухамхүү Смирновыг буудан алах гээд байгааг тааж цөхөх юмгүй. Иван Никитич Смирнов 1899 онд 17 насандаа намд элссэн, хаант засгийн шорон, цөллөгт олон жил суусан хуучин ажилчин, идэвхтэй нууц хувьсгалч, иргэний дайнд Колчакийг дарсан хүн, хэдийгээр сөрөг хүчинтэй хэсэг зуур нэгдэж байсан боловч намын дотор гойд нэр хүндтэй. Харин Сталиныг Ерөнхий нарийн бичгийн даргаас өөрчлөх тухай Лениний шаардлагыг биелүүлэх гэж тухайн үед их улайсан хүн. Сталин түүнд хэрэг тулган хүлээлгэснээр шүүх ажиллагааг илүү үнэмшилтэй болгохын зэрэгцээ өсч сэтгэлийнхээ бахыг бас хангана.

Сталин бүр иргэний дайны үеийн хоёр найзыг ханинд нь мөрдөхийг даалгасан нь тэдний нөхөрлөлийг хамсаатны холбоо сүлбээ болгон гуйвуулах гэсэн санаа. Нэмэрт нь Мрачковский Смирновын үгнээс гардаггүй учраас Смирнов буугаад өгвөл Мрачковский ч бууж өгнө. Энэ хэргийг мөрдөх болсон Слуцкий ийм удирдамжтай эхлэв.

Слуцкий гадаад хэлтсийн дарга, дээгүүр зиндааны түшмэл учраас ДЯАК-ын удирдлагын нэрийг барьж ярина. Смирнов Мрачковский хоёрыг аргаар үзнэ үү гэхээс биш эрүү шүүлтний хатуугаар нугална гэж байхгүй. Аргыг олж магадгүй хүн бол Слуцкий мөн. Төрөлхийн жүжигчин шинжтэй, сайхан халгиж цалгина.

Гэтэл алан хядах үйл ажиллагаанд оролцсоны учир яллах гэж байгааг Смирнов сонсоод,

-Наадахь чинь бүтэхгүй. Би 1933 оны нэгдүгээр сарын 1-нээс шоронд сууж байгаа, та нар миний эсрэг юу ч нотлож чадахгүй гэж өчжээ.

-Иван Никитич, бид ерөөсөө ямар нэг юм нотлох гэсэн юм биш гэж Слуцкий эелдэгхэн өгүүлэв. -Та хэргээ хүлээхгүй бол шүүх хурал энэ тэр гэхгүй шууд Онцгой зөвлөлгөөний тогтоолоор таныг буудан ална. Шүүх хурал дээр бусад яллагдагсад таныг алуурч, алан хядагч гэдгийг жигшин илчилж, Зөвлөлтийн ард түмэн таныг тийм л байдлаар тогтоож авна. Харин та Улс төрийн Товчооны саналыг биелүүлж, Троцкийг бүрмөсөн илчлэхэд намдаа туславал амь насыг тань хэлтрүүлж, яваандаа танд дүйцэх нэр төртэй ажил өгнө, тэгээд эцсийн эцэст бүх юм мартагдана.

Смирнов тохуурхсан янзтай түүнийг чимээгүй харлаа.

-Та надад итгэхгүй байна уу? гэж Слуцкий асуув.

Смирнов нэг ч үг дуугарахгүй, нөгөө л янзаараа түүнийг харсаар.

-Иван Никитич хэмээн Слуцкий улам эелдэг царайлав. -Та 27 оноос хойш намтай тэмцэж байна, одоо юу юугүй арван жил болох нь. 1929 онд та сөрөг хүчнээс салсан л даа, гэхдээ зэвсгээ бүрмөсөн орхиогүй. Үүнээс болоод даруй арван жил та социалист байгуулалтад оролцохгүй байна, та намын бахархал, ажилчин ангийн бахархал байтлаа арван жил ард түмнээс тусгаарлагдаж, шорон, цөллөгөөр хоног төөрүүлж байна. Гэтэл энэ хар дарсан зүүд шиг юмнаас ганц дохиод салах боломж танд байна. Иван Никитич, та сайн бод! Яг ангалын ирмэг дээр ирчихээд байна шүү. Ийм сайхан баатарлаг амьдралыг ингэж арчаагүй төгсгөх юм уу? хэнээс болж гээч? Лев Давыдовичоос болж уу? Гэтэл тэр чинь нэгэнт өнгөрсөн. Чухамдаа та бол сөрөг хүчнээс хэлбэрийн хувьд ангижирсан шүү дээ... Одоо жинхэнэ дээрээ салчих! Троцкийг бутниргэхэд намдаа туслачих. Үүний тулд та зарим эвгүй зүйлийг, шившигтэй зүйлийг хүлээх ёстой болно, танд огт падгүй зүйлийг ч хүлээх ёстой болно, би үүнийг мэдэж байна. Гэвч өөр арга зам алга. Та намынхаа итгэлийг сэргээж авъя гэж байгаа бол төлөх ганц үнэ байна. Тэр бол мөрдөн байцаагчийн шаардаж байгаа зүйлийг хүлээн зөвшөөрөх асуудал. Өөр үнэ байхгүй. Иван Никитич, та сайн бод! Би танд мөргөж гуйя. Би таныг яаж хүндэлж, яаж биширдэгийг та төсөө-лөхгүй. Иван Никитич, би таны өмнөөс ёстой айхын цаагуур айж байна. Та гомдсон, та хорссон, та нэр төрөө бодож байгаа, би ойлголгүй яахав, гэхдээ коммунистын хамгийн нэр төртэй хэрэг бол намынхаа ашиг сонирхлыг

хамгаалах явдал, та намынхаа өмнө номхор, эс тэгвэл таныг арчаагүй үхэл л хүлээж байна. Энэ хэнд хэрэгтэй юм бэ, Иван Никитич?

Смирнов дуугарахгүй түүнийг хямсайсхийн харсаар байв.

Слуцкий санаа алдав.

-За яая гэхэв, би танд бүх юмаа хэлчихлээ. Бүх юмаа шүү, та үнэмшвэл сайн байна, Иван Никитич. Би эрхээ хэтрүүлж, хариуцлагыг өөртөө авч зөндөөн юм илүү хэллээ. Нэгэнт хэлснийх давтаад нэг хэлчихье. Танд хоёрхон зам байна, коммунистынхаа үүргийг биелүүлж нийтийн өмнө шудрагаар хэргээ хүлээвэл та амьд үлдэнэ, амьд явбал алтан аяганаас ус ууна гэдэг, бууж өгөхгүй бол Зөвлөлт засгийн дайсан болж буудан алуулна.

Иван Никитич хүний урманд ганц үг дуугарах царай алга.

Слуцкий ийнхүү бүдэрсэнд Ягода, Агранов, Молчанов нар сэтгэл их дундуур байв. Дундуур ч байхаас яахав, уул нь Сталин Мрачковскийгээс эхлэх хэрэгтэй гэж чиглэл өгсөн, түүнийг зөрчсөн хэрнээ ямар ч үр дүнд хүрсэнгүй. Слуцкийн аймхайг ч хэлэх үү, алдаагаа бушуу засах юм болов.

Тэрээр Мрачковскийд хэргийн учрыг тайлбарлаж түүнд хоёрхон сонголт буйг албан ёсоор мэдэгдэв: нэг бол намдаа туслаж, тэгснээрээ түүний эгнээнд буцаж орох, эсвэл Троцкийн талыг баримтлагчийн хувьд устгуулах. Өөрөөр хэлбэл, намтайгаа хамт Троцкийн эсрэг тэмц, тэгвэл амь нас ч үлдэнэ, ирээдүй ч үлдэнэ, эсвэл Смирновтой хамт намын эсрэг тэмц, тэгвэл амь нас ч үгүй, ирээдүй ч үгүй болно. Би, Слуцкий бол энд зөвхөн мөрдөх байгууллагын нэрийн өмнөөс, албан үүргийнхээ дагуу юу ярих ёстойг л ярьж байна. Харин Мрачковский татгалзахгүй бол би, Слуцкий хувь хүнийхээ хувьд юу бодож байгаагаа хэлбэл хэлэх байна.

-Ярь л даа гэж Мрачковский дуугарав.

-Сергей Витальевич хэмээн Слуцкий сэтгэл хөдлөм эхлэв. -Та иргэний дайны баатар, манай ард түмэн, улс орон, манай нам үүнийг сайн мэднэ. Та бол цэргийн үнэхээр том жанжин, хэрвээ сөрөг хүчинтэй нийлж яваагүй бол та өдийд гарцаагүй манай армийн нэг удирдагч болчихсон байгаа. Та бидний шаардлагыг хүлээж авбал шүүх хурал дээр хэдэн өдөр муугаа үзнэ, тэр бол дамжиггүй. Гэтэл дараа нь... Дараа нь дайн тулаад ирнэ, Сергей Витальевич минь. Гитлер юунд бэлтгээд байгааг та сайн мэднэ шүү дээ. Тэгээд дайн эхлэхийн цагт Сергей Витальевич та эх орноо хамгаалах үйлст нэртэй төртэй байраа эзлэнэ, өөрийнхөө мэдлэг чадвар, туршлага, авьяас билигт дүйсэн байр сууриа эзлэнэ. Шүүхийн энэ хэдэн өдрийг хэн санах юм бэ? Одоо хэлэх гэж байгаа үгийг хэлэхэд надад тун хэцүү байна, гэхдээ би заавал хэлэх ёстой. Таны өмнө хоёр сонголт байна: яруу алдарт амьдрал, эсвэл ямар ч арчаагүй үхэл.

-Би юун дээр гарын үсэг зурах ёстой вэ? гээд Мрачковскийн царай барайлаа.

Мрачковский шаардлагатай мэдүүлгийг өгөөд зогссонгүй, Иван Никитич Смирновыг ятгахаар болжээ. Гэвч тэр нь бүтсэнгүй. Тэр хоёрыг нүүрэлдүүлсэн чинь Смирнов

Мрачковскийг хулчгар амьтан гэж зүхээд түүнтэй ганц үг ч солихоос татгалзжээ.

Уур нь шатсан Мрачковский бүр 1932 онд нэг нууц зөвөлгөөн дээр Смирнов Зиновьевчуудтай нэгдэж, алан хядах тактикт шилжихийг санал болгож байсан мэтээр Смирновын эсрэг нэмэгдэл мэдүүлэг өгчээ.

Ингэснээр Смирновын эсрэг Ольберг Рейнгольд хоёрын өгсөн мэдүүлэг дээр хамгийн дотных нь нөхөр Мрачковскийн мэдүүлэг нэмэгдэх болно. Энэ бүхэн Смирновыг шүүх хурлаар шүүхэд хангалттай байсан байж магадгүй, харин мань хүнээр хэрэг албадан хүлээлгэхэд үнэндээ хангалтгүй юм.

Слуцкий бүтэлгүйтсэн учир Смирновыг онцгой хэлтсийн дарга Гайд шилжүүлжээ.

Ольберг, Рейнгольд, Дрейцер, Гольцман, Мрачковский нарын төдийгүй Зиновьев, Каменев хоёрын (энэ нь үнэн, Зиновьев, Каменев хоёр хэдийн мэдүүлэг өгчихсөн) аль алиных нь мэдүүлгээр Смирнов бүрэн дүүрэн илчлэгдсэн, тэдний мэдүүлгийг нотлож, буруугаа хүлээх л үлдсэн гэж Гай түүнд түс тас хэлжээ.

Хэлсэн үгнийхээ баталгаа болгож Зиновьев, Каменев хоёрыг байцаасан протоколоо Смирнов руу сарвайв.

-Унш даа.

Гэтэл Смирнов тэдгээрийг уншихаас татгалзаж,

-Та нарт чадахгүй юм байхгүй, намайг алан хядагч гээд нотлочихсон Евангели судар ч та нар надад үзүүлж чадна. Ийм юм хэвлэх хэвлэх үйлдвэр танайд олон бий гэж өчжээ.

-Үнэмшихгүй байна уу? Одоо үнэмших болно гэж Гай тамшаалав.

Тэгээд харилцуураа авч нэг хүнтэй ойлгомж муутай хэдэн үг сольсноо утсаа тавьчихаад нэг юм бичих аядав.

Төдөлгүй хаалга тогшлоо.

-Ороорой! гэж Гай хашгирах шахам хэлэв.

Хаалга нээгдэж харуулын хамт, хөл дээрээ тогтож ядсан, амьсгаа

нь бахардсан, сэлхэрсэн цонхигор царайтай хүн орж ирэв. Смирнов түүнийг Зиновьев гэж тэр даруйдаа таньсангүй.

Харуул дэмжиж байж түүнийг сандал дээр суулгав.

-Иргэн Зиновьев, та мөрдөн байцаалт дээр Иван Никитич Смирновыг “Нэгдсэн төв”-ийн алан хядах үйл ажиллагаанд оролцсон тухай мэдүүлснээ нотлож байна уу? гэж Гай асуув.

-Нотлож байна гэж Зиновьев сонсдох төдий хэлэв.

-Гэтэл иргэн Смирнов үгүйсгэж байна гэж Гай хэлэв.

Зиновьев гөлөрсөн харцаа Смирнов руу хандуулж,

-Иван Никитич, улс төрийн үүднээс эргэцүүлж бодох хэрэгтэй. Хэрвээ бид Кобад сэтгэлээ нээвэл Коба ч бидэнд сэтгэлээ нээнэ. Ингэснээр бидний өмнө намын хаалга нээгдэнэ гэж аяархан өгүүлэв.

-Тэр бидний хойт насны хаалгыг л нээж өгнө. Чи Кобаг мэдэхгүй гэж үү дээ? Чи түүнд итгэж байна уу? Тэр чинь худалч, хууран мэхлэгч. Биднийг үгүй хийх гэж л ийм юм сэдээ шүү дээ гэж Смирнов хариулав.

-Эргэлзэж байна, харин үгэнд нь орохгүй бол тэр чамайг гарцаагүй үгүй хийнэ гэж Зиновьев шуухитнан шивнэв.

-Худалч, хулчгар, шарваач шар жингэр болж үхсэнээс шудрага хүн чигээрээ үхсэн нь дээр.

Гай энэхүү нүүрэлдсэн уулзалтын тухай Смирнов алан хядах ажиллагаанд оролцсон талаар Зиновьев түрүүчийнхээ мэдүүлгийг дахин дахин нотлоход Смирнов туж үгүйсгэсэн гэх маягийн протокол үйлдэв.

Зиновьевыг аваад гарцгаав.

Гай ширээн дээрх цаасаа эмхэлж нааш цааш нь болгох зуур санаандгүй мэт,

-Сафоноваг мэдэх үү? гэж асуув.

Смирнов анх удаа толгойгоо өлийв.

-Сафонова гэдэг нэрийг та мэдэх үү? гэж Гай давтан асуув.

-Мэднэ. Миний түрүүчийн авгай.

-Тэгвэл үүнийг унш даа.

Өгсөн цаас нь Сафоновагийн мэдэгдэл байх бөгөөд түүнд Смирнов шоронд орохоосоо өмнө бүр 1932 оны сүүлчээр нам, засгийн удирдагчдын эсрэг алан хядах ажил зохион байгуулах удирдамж Троцкийгээс авсан гэж нотлон бичжээ.

-Энийг ч бас та нар зохиож чадна гээд Смирнов тэр цаасыг буцааж шидэв.

Гай хонхоо дарж, гэрч Сафоноваг авчрахыг харуулд даалгав.

Сафонова орж ирлээ. Смирнов түүнийг ойрд хараагүй, тухайн үедээ тэр хоёр эв зүйгээр салж, сайн нөхөд хэвээр үлдсэн билээ.

Сафонова байцаагчийн заасан сандал дээр сууснаа уйлчихав. Смирнов хуучин авгайгаа уйлж байхыг хэзээ ч үзээгүй аж. Тун эрэмгий явсан хүүхэн. Одоо уйлаад зогсдоггүй, Гай ч удаан уйлах тусмаа сайн гэж байгаа бололтой юу ч хэлсэнгүй. Авгай тэгж тэгж биеэ барин, нулимсаа арчив.

Смирнов нөгөө мэдэгдэл рүү дохиж,

-Чинийх үү? гэж асуулаа.

Сафонова дахиад мэгшмэр аядсанаа нулимсаа арчиж,

-Иван! Бидэнд өөр зам байхгүй. Чамд ч байхгүй, Розад (шинэ авгайг нь хэлж байна) ч байхгүй, Ольгад (охиныг нь хэлж байна) ч байхгүй. Зөвхөн чи л бидний амь насыг аварч чадна, Улс төрийн Товчооны үгэнд ор. Энэ шүүн таслах ажиллагаа Троцкийн эсрэг чиглэсэн нь хэнд ч ойлгомжтой. Зиновьев, Каменев хоёр хүртэл үүнийг ойлгочихоод байна. Хэрвээ чи шүүхэд очих юм бол бүх дэлхий чамайг харна, тэгвэл чамайг буудан алж чадахгүй, харин шүүхэд очихгүй бол чамайг ч буудан ална, манийг ч буудан ална, гэтэл энэ тухай хэн ч мэдэхгүй хоцроно.

Смирнов чимээгүй сонслоо. Энэ бол цагтаа зарчимч, аймшиггүй, нугарашгүй, аялдан дагадаггүй хүүхэн байсан, мань хүн хичнээн хүндэтгэдэг байлаа, гэтэл түүнийг нухлан дарж, үхтэл айсан, жирийн нэгэн эм болгочихож.

-Энэ мангууг холдуулж аль гэж Смирнов хэлэв.

-түүнтэй яримааргүй байна уу? За яахав, таны дур мэдэг хэмээн Гай жуумалзав.

Тэрээр харуулыг дуудаж Сафонова руу заагаад,

-Аваад яв! гэж хэлэв.

-Иван!

-Тонил! гэж Иван Никитич ширэв татлаа.

Сафоноваг авч гарсны дараа Гай,

-Та түүнтэй бүдүүлэг харьцаж байна. Танд өөр төрөл төрөгсөд бийг битгий мартаарай. Тэд нартайгаа бас ингэж харьцах юм уу? гэж тавлангуй асуув.

Иван Никитич дуугарсангүй. Гай юун тухай яриад байгааг сайн ойлгосонгүй. Сафонова бол хуучин намын гишүүн байсан, улс төрийн зүтгэлтэн хүн, гэтэл өөрийнх нь одооны гэр бүл ямар хамаа байна? Гэргий Роза нь нам бус, охин нь оюутан, тэд нар өөрийнх нь хэрэгт ямар хамаа байна?

Энэ тухай Иван Никитич аравхан минутын дараа мэдэж авлаа. Шоронгийн хонгилоор туугдаж явахдаа тэртээ мухрын хавьд охин нь байгааг гэнэт олж харав. Үс гээг нь сэгсийж,

даашинз нь урагдаж, нүднээс гарсан хөөрхий Ольгаг хоёр мангар харгалзагч шахаж бариад зогсож байх нь тэр. Ольга аавыгаа таниагүй байх, лав л зүтгэлсэнгүй, харин Иван Никитич тийшээ ухасхийтэл харгалзагчийн төмөр мэт гар араас нь тас зууран авав. Ольгаг тэр даруй өрөө рүү нь чирч оруулаад хаалгыг нь хаалаа.

Иван Никитич сулрах гэж баахан сэгсчсэн боловч харгалзагчид өрөө рүү нь хүчээр түлхэн оруулж шалан дээр хаялаа.

Түгжээ торхийн хаагдав.

Иван Никитич босч хаалга балбалаа.

Шагайвч нээгдэж, хонгилын харуул түүгээр цухуйв.

-Яагаад хаалга нүдээд байна?

-Намайг мөрдөн байцаагч руу буцааж аваач!

-Байрны ахлагчид хэл.

-түүнийгээ дууд!

Шагайвч хаагдлаа.

Иван Никитич орон дээрээ суулаа. Тэр муу үхээнц Гай ийм юмаар заналхийж байсан байх нь. Яг толгойлогч Сталин шигээ эрүүгийн хэрэгтэн байна. Сталин шоронд байхдаа эрүүгийн ялтнуудтай нөхөрлөдөг байсан юм чинь. Гэхдээ одоохондоо охиныг нь сүйд хийчихээгүй байна, харин зөрүүдлээд байвал охин чинь юу болохыг мэд хэмээн сүрдүүлж байна. Энэ бүтэхгүй бол дараа нь ямар ч арга хэрэглээд нэмэргүй гэдгийг тэд ойлгож байгаа, одоохондоо охинд нь заналхийлж байна, дараа нь авгайд нь заналхийлнэ. Гэхдээ зангаад зогсохгүй ажил болгож мэднэ, тэгвэл өөрийг нь ямар ч мөрдлөг, ямар ч шүүх хуралгүйгээр буудаад алчихна. Өөрийнх нь амьдрал дуусчээ, энэ бол тодорхой байна, гарын үсэг зурсан, зураа-гүй дуусна. Сталин түүнийг буудан ална, энэ тодорхой. Тэгэхээр авгай, охин хоёроо аврах хэрэгтэй. Яльгүй буулт хийх хэрэгтэй. Бага шиг буулт хийхэд л тэдний санаа ханана. Зөвшөөрнө. Шүүх хурал дээр мань хүнийг гаргах нь тэдэнд үнэхээр чухал. мань хүн оролцохгүй бол “Нэгдсэн төв” гээд байгаагийнх нь Троцкийтэй холбогдох хэсэг байхгүйтэй адил болно. Зиновьев, Каменев хоёр есөн жил бүх нүглийг хүлээн гэмшиж байгаа, одоо ч тушаасан бүх-нийг хүлээхэд бэлэн байгаа. Харин өөрөө бол Сталины үнэ цэнийг мэдэх учраас хэзээ ч нүгэл хүлээж гэмшиж яваагүй. 1929 онд сөрөг хүчнээс хөндийрөхдөө Сталин сөрөг хүчний саналыг хүлээж авлаа, баруунтантай тэмцэл хийх нь, одоо нам, сөрөг хүчин хоёр зөрөх юмгүй боллоо, ийм нөхцөлд намынхаа төлөө ажиллах ёстой гэж шийдсэн юм. Тэгээд алдаагаа тун удалгүй ойлгосон. Сталин арга саам хийж байгаад сөрөг хүчнийг улс төрийн хувьд устгасныхаа дараа сөрөг хүчинд байсан бүх хүнийг шоронгийн тав болгочихсон. Одоо болохоор толгой дараалан устгах нь. мань Смирновыг ч устгах нь мэдээж. Тэгэхээр мань хүн гэр бүлээ аврах ёстой. Үүний тулд шүүхэд очно гэсэн үг. Очихоос ч яахав. Ингэснээр дуулгавартай яллагдагсад, урваач гэрч нарын өөр рүү нь тулгах гүтгэлгийг аль нэг

хэмжээгээр сааруулна. Өөрийг нь ялтны суудалд суулгахын тулд Сталин энэ жүжгийнхээ зарим зүйлийг өөрчлөхөөс аргагүй болно.

Смирнов Троцкий 1932 онд алан хядах ажиллагаа явуулах чиглэл өгсөн гээд байгааг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байгаагаа Гайд мэдэгдэв. Гэхдээ Смирнов өөрөө шоронд сууж байсан болохоор алан хядах ажиллагаанд огт оролцоогүй, бусад яллагдагсад оролцсон эсэхийг мэдэхгүй. Үүний хариуд охиныг нь нэн даруй суллаж гэрт нь хүргүүлэх, тэгсэн эсэхийг шалгах боломж өөрт нь олгохыг шаардаж байна хэмээжээ.

Гай энэ болзлыг хүлээн авчээ. Смирновыг хоёр цаг орчмын дараа Гай дахин дуудаж, гэр рүүгээ утасдахыг санал болгов. Смирнов ч утасдаж. Авгай нь утсаа авч, дараа нь охиндоо өгч. Өөрийнх нь тухай цаадуул нь асуухад,

-Дажгүй ээ гэж Смирнов хариулав.

Смирнов Гайн дэргэдээс өдөр бүр гэр рүүгээ утасдаж, авгай охин хоёр нь гэртээ байгааг мэдэж авдаг болов.

Угаалгын газрын хүлээн авах тасагт гурван эмэгтэй ажиллана. Нэг нь цагаан хэрэглэл хүлээж авна, нөгөө нь тавьж өгнө, гуравдахь нь баримт бичиж, мөнгө хураана.

Софья Александровнаг тавьж өгөх ажил дээр шууд томилжээ. Яршигтай хэцүү ажил. Баглаатай цагаан хэрэглэл хүндийг хэлэх үү, үйлчлүүлэгчтэй хэл амаа ололцоно гэж бүр хэцүү. Нэг юм дугчихна, хооронд нь хольчихно. Ихэнхдээ угаалгын газрын буруу, гэхдээ хүлээн авагч Люсягийн буруу байх нь ч бий.

Баримт бичиж мөнгө хураах ажилтай, эднийхээ ахлагч маягтай тооцогддог Тамара Федоровна гэж дуу цөөнтэй, ахимаг насны хэдэрдүү авгай Люсад заримдаа анхааруулна. Люся залуухан, шазруун охин, тас зөрнө:

-хүний баастай өмдийг би үнэрлэж байх албатай юм уу!

Софья Александровна санаа алдахаас цаашгүй. Нэгдэж, биеэ өмөөрч сураагүй, хоёрдож, улайм цайм илт юмыг яаж маргаж байхав, дутаасан буюу гологдол гарсан бол шууд л акт бичээд гарын үсэг зурчихна. Эрхлэгч Яков Григорьевич энэ мэтэд их дургүй. Сав л хийвэл,

-Танаас өмнө ямар ч гомдол гардаггүй байсан. Ааштай, авиртай болгоны үгийг дагалаа. Үйлчлүүлэгчид ойлгуулахын оронд над руу хамаг юмаа чихэж байна. Би таны өмнөөс ажиллах ёстой юм уу гэхчилэн загнана.

Өдөр ирэх тусам энэ байдал дордсоор. Санал гомдлын дэвтэрт угаалгын чанар муу гэдгээс гадна хүмүүсийн харьцаа муу гэж гомдоллосон зүйл элбэгшлээ.

Яков Григорьевич нэг удаа,

-Таны тухай гомдол мэдүүлсэн байна, арга хэмжээ авна даа гэжээ.

-Энэ ажил надад хүнддээд байна, би зүрх муу, намайг чөлөөлж өгөөч гэж Софья Александровна хариулав.

-Өвчтэй юм бол эхлээд тахир дутуугийн бүлэгт орох хэрэгтэй.

-Өөрийнх нь хүсэлтээр чөлөөлж болно биз дээ гэж Тамара Федоровна хөндлөнгөөс гэнэт хошуу нэмэв.

-Тэгвэл орных нь хүн хаана байна?

-Бод л доо! Бодохын тулд та эрхлэгч хийж байгаа. Нас ахисан, бие муутай хүнийг харсаар байж, тохуурхаж байгаа юм уу, хаашаа юм бэ?

-За, за, Тамара Федоровна, та жаахан амаа мэдээрэй, хэнийг хамгаалж байгаагаа мэдэх үү? Наадахыг чинь хэн ч ажилд авахгүй, хүү нь хориход байдаг юм чинь.

-Хориход биш ээ... гэж Софья Александровна эхлэтэл Тамара Федоровна үгийг нь тасдав.

-Авах уу, үгүй юу гэдэг бол Софья Александровнагийн санаа тавих асуудал. Харин танд хөдөлмөрчин хүнийг тохуурхах эрх байхгүй, Зөвлөлт засгийн үед аж төрж байна!

-хэн бэ, хэн тохуурхаа вэ? гэж Яков Григорьевич бугнав.

-Та! Та тохуурхаж байна. Бид гэрчлэнэ шүү.

-Зүйтэй, яг гэрчлэнэ гэж Люська гэнэт мэдэгдэв. Яков Григорьевич чимээгүй хэсэг азнаснаа, царай нь барайн, Софья Александровнад хандаж,

-Өөрийнхөө хүсэлтээр халагдах өргөдлөө гарга даа хэмээв.

Софья Александровна угаалгын газрынхаа ажлыг ийнхүү дуусгажээ.

Шинэ ажилд орох асуудал босч ирлээ.

Хоёр дүүтэйгээ зөвлөж. Орцныхоо хөгшин армян авгай Маргарита Артемовнатай зөвлөж. Мэдээж, Варятай зөвлөж.

түүнийг угаалгын газраас гарсанд Варя баяртай байв.

-Танд суугаа, тайван ажил хэрэгтэй.

-Тийм ажил хаанаас олох вэ?

-Эрж хайцгаая.

Варягийн толгойд хамгийн түрүүнд Вика Марасевич орж ирэв. Нөлөө бүхий олон танил нь туслаж чадна даа. Эцэг нь бас энүүхэн Гагарины гудамны эмнэлэгт зөвлөлгөө өгдөг юм чинь Софья Александровнаг ажилд оруулаад өгч магадгүй.

Варя Вика руу утасдав. Вадим утас авсныг Варя дуугаар нь шууд танив.

-Сайн уу, Вадим...

-Сайн, сайн байна уу... хэн бэ?

-Варя Иванова байна, санаж байна уу? Нинагийн дүү.

-А-аа... хэмээн Вадим хайнга дуугарав. -Та юу гэв?

-Би Викатай ярих гэсэн юм.

-Вика байхгүй.

-Хэзээ байх бол?

-Хэзээ ч. Москвад аж төрөхөө больсон.

-Өө, тийм үү.

-Харин тийм. Баяртай. Нинад мэнд хүргээрэй.

Ингэж хэлээд утсаа тавьчихав.

Шижээргүй байдалтай ярилаа. Хачин юм. Викад ямар нэг юм тохиолдсон юм болов уу?
Шоронд хийчихээ юү?

Уран барилгач нөхрийнх нь нэр сонин дээр үзэгдсээр байгаа, тэгэхээр тэр мөрөөрөө байгаа гэлтэй... Викад юу тохиосон юм бол?

Вика хүнтэй суугаад хилийн чанад руу явчихсаныг Варя хожим дуулжээ.

Харин тэрхэн үедээ түүнийг олж чадаагүйдээ Варя хэрхэндээ гутарчээ. Туслаж чадах хүн гэж бодсондоо тэр.

Варя Зояд хүртэл хэлж үзжээ. түүний ээж кинотеатрт билет шалгадаг учраас тиймэрхүү ажил олдохыг хэн байг гэхэв. Зоя үүнийг далимдуулан Варятай эргэж дотносоно гэж горьдсон уу, ямар ч атугай, хоёр долоо хоног хэртэй хөөцөлдөж байгаа дүр үзүүлэн чулуу хөөлгөжээ.

Игорь Владимировичаас гуйх болох нь. Варя түүнээс үнэхээр юм гуймааргүй байгаа билээ. Нөгөө нэг цэцэгний явдлаас хойш тэр хоёрын харилцаа өөрчлөгдсөн. Одоо иймэрхүү асуудлаар түүнд хандвал буруу ойлгогдож мэднэ гэж Варя санаа зовжээ.

Гэвч өөр зам байсангүй.

-Манай байшингийн нэг авгайг би сайн таньдаг, хайрлаж хүндэтгэж байдаг юм хэмээн Варя эхлэв. -Ганц бие, сайхан сэтгэлтэй, шудрага авгай. Нөхөр нь салаад удаж байгаа, хүү нь уржнан баригдсан юм. Одоо гав ганцаараа. Амьжиргаа залгуулах орлого байхгүй. Уул нь угаалгын газар цагаан хэрэглэл тавьж өгдөг байсан юм, тархи толгойд нь яршигтай, хүнд ажил. Тэндээсээ арга буюу гарсан. Гимнази төгссөн, боловсролтой авгай, бичиг хэргийн ямар ч ажлыг амжуулна. Манайд ч юм уу, эсвэл өөр аль нэг зураг-төслийн байгууллагад түүнийг ажилд оруулж болохгүй юм болов уу? Та туслаж чадах болов уу? Уг нь Арбатаас холгүй бол зүгээр сэн, трамвайн дүүрэг болдгийг та эс мэдэх биш.

-Манайд уу? хэмээн Игорь Владимирович зөрүүлэн асуув. -Варенька, зочид буудлын барилга дууссан, манай товчоо өөр барилгын зураг-төсөл рүү шилжинэ. Өөрчлөн байгуулах тухай ч яриа бий, асуудал шийдэгдсэн тухайд нь ямар нэг юм хийх гэж оролдож болох байх. Өөр газрын тухайд гэвэл би... би асууж сураглая л даа. Таны харж үзэх гээд буй хүн чинь юу хийж чадах вэ? Ингэхэд, нэр овог нь хэн билээ?

-Панкратова Софья Александровна.

Тэрээр хуанли дээрээ тэмдэглэж авав.

-За, тийм байж! Тэгээд юу хийж чадна гэнэ ээ?

-Бичиг хэргийн ямар ч ажил. Цаас үдэх, бүртгэх... хэн нэгний нарийн бичиг хийсэн ч чадна, их хичээнгүй нямбай хүн байгаа юм. Тоо бүртгэгч, мөнгөний нярав... Үгүй ээ, мөнгөний нярав хэрэггүй. Мөнгөө буруу зөрүү тоолчихож мэднэ. Бүртгэгч байж болно.

-Ямар нэг мэргэжил бий юү?

-Яг сайн мэдэхгүй юм байна. Сүүлийн үед угаалгын газар ажиллаж байсан, гэхдээ тэр бол тохиолдлын ажил. Гэрт нь ойрхон гэж л сонгосон хэрэг.

-Би ямар нэг юм олж мэдэхийг оролдъё. Гэхдээ миний бодоход, манай өөрчлөлт хийгдэж, шинэ орон тоо батлахыг хүлээх нь арай бодитой болов уу. Энэ авгайн тухайд та санаа их зовж байгаа юм аа даа гээд Игорь Владимирович инээмсэглэв.

-Тийм ээ, миний дотнын хүн байгаа юм. Их зовж яваа хүн. Туслахгүй бол болохгүй гэж Варя өчив.

Варя тэр орой нь Софья Александровнад энэ тухай ярьжээ. Хэдийгээр энэ хувилбар бүтнэ гэж сайн итгэхгүй байгаа ч Софья Александровнад найдлага төрүүлж урам нэмье гэсэндээ тэр.

-Софья Александровна, ингэхэд танд ямар нэг мэргэжил байна уу? Манай дарга тэгж асуусан юм.

-Мэргэжил ий? Варечка минь, надад тодорхой мэргэжил байхгүй ээ. Гимнази төгссөн... Хэдэн онд билээ? 1910 онд. Консерваторид орно гэж боддог байлаа... Надад хоолой байсан юм. Гэтэл хүнтэй суучихлаа, Саша маань төрчихлөө. Дараа нь дайн, хувьсгал. Сашаг овоо болсон хойно хорин хоёр билүү гурван оноос би ажил хийсэн, ажил хийх ч биш л дээ, хэд гурван цаас олдог байсан гэх үү дээ. Сашагийн эцэг Павел Николаевич бүх юм жин тан байх ёстой гэдэг хатуу шаардлагатай хүн. Хоол, цай яг цагтаа бэлэн байх ёстой. Гэр орон цэвэр цэмцгэр байх ёстой. Хувцас хунар нь угаасан, индүүдсэн байх ёстой. Тэгээд би байнгын ажилд орж чаддаггүй. Гэрээсээ нэг их хөндийрөхгүй ойр зуурын ажил хайдаг байсан юм. Нэг үе сугалаа тараадаг байлаа. Волга орчмын өлсгөлөнгийнхөнд туслах сугалаа гэж байсныг санаж байна. Айл болгоноор орно, цахилгаан шат тэр болгон ажиллахгүй, гэхдээ залуу байсан болохоор яаж ийгээд амжуулна. Гэр орныхоо ажлыг, мэдээж, орхихгүй. Үнэндээ бол, цөөхөн юм олно. Борлуулсан сугалаанаас хувиар бодож өгнө. Дараа нь озонатор зардаг байлаа.

-Тэр чинь юу вэ?

-Жорлонд өлгөчихдөг, эвгүй үнэрийг нь дардаг эд. Хориод оны дундуур нэг үе их дэлгэрсэн юм. Тэгсхийгээд моодноос гарчихсан. Инээдтэй юм их гарна. Нийтийн байрныхан бол цөмөөрөө санал нийлж байж авна. Уул нь 2-3 рублийн үнэтэй, хямдхан л даа. Гэтэл нэг нь л авахгүй гэвэл тухайн байрныхан тэр чигээрээ авахгүй. Тэр муу маний мөнгөөр сайхан үнэр үнэртээд байх юм уу? Тэгж ярих-гүй! Цөмөөрөө хоосон байя гэх жишээтэй. Даатгалын

төлөөлөгч хийж үзсэн. Амь нас, эд хогшил гэхчилэн даатгал хийнэ. Ер нь боломжийн ажил. Гэхдээ манайхан даатгуулах дургүй, заримдаа бүтэн цаг ятгах хэрэг гарна. Нөгөө хүн чинь олон юм ярина. Би юугаа даатгуулах юм бэ? Миний эд хогшил гэж юу байна? Ганц төмөр ор, ширээ, гурван сандал. Ер нь туйпуун байшинд ямар юмных нь түймэр байх вэ? Ярилцах ч бас яахав. Шууд хөөгөөд гаргах тохиолдол ч бий. Би хэдийгээр мэрэгжлийн сургууль хийгээгүй ч намайг радиод дуулуулах гэж урьсан тал бий, гэвч Павел Николаевич тас хориглосон. Ингээд, Варенька минь, би гэдэг хүн мэргэжилгүй хоцорсон юм, үгүй ээ, гэрийн эзэгтэй гэдэг хамгийн хээгүй мэргэжилтэй хоцорсон гэж хэлэх нь зүйтэй байх.

Софья Александровнагийн дүү Вера эрч хүч ундарсан ажилсаг хүүхэн эгч дээрээ ирээд угаалгын газраас гарсныг олзуурхан сайшаав.

-Гарсан чинь зөв. Чамд тэнцэхгүй ажил. Өөр амар, хөнгөн ажил хайхад олдоно. Одоохондоо тэснэж бай. Харин зөрүүдэлдэгээ боль. Үгүйдээн, Сашагаа бод л доо.

Зөрүүдлэх гэдэг нь Марк Александровичийн өөрт нь гуйвуулж байгаа мөнгийг Софья Александровна авахаас татгалзаад байгааг хэлсэн хэрэг. Уул нь яг өөрт нь ирүүлэхгүй байгаа л даа. Хамгийн түрүүчийн шилжүүлснийг мань хүн шууд буцаачихсан юм. Тийм учраас Марк Александрович Соня эгчдээ зориулсан мөнгөө Верагийн нэрээр сар болгон гуйвуулж, түүнийг Соняд ятгаж ойлгуулахыг хүсдэг билээ.

Гэвч Софья Александровна нөгөө мөнгийг нь авдаггүй учраас Вера арга буюу хадгаламжинд аваачиж хийнэ.

-Чи яагаад Маркаас мөнгө авахгүй гээд байгаа юм бэ? Тал талаас нь сайн бодох хэрэгтэй. Сашагийн тухай нэг тиймэрхүү юм хэлээ л биз. Гэхдээ чи түүний байдлыг ойлго. мань хүн Сашагийн төлөө юм хийх гэж оролдсон, гэхдээ юу ч хийж чадахгүй нь тодорхой. Хамгийн мундаг дарга нартай хүртэл ярьж үзсэн гэсэн, надад түүнд итгэхгүй байх шалтаг алга.

-түүний мөнгө надад хэрэггүй.

-За тэгж саная. Чамд хэрэггүй байж. Тэгвэл Сашад? Хугацаа нь дуусах гэж байна. Москвад суухыг түүнд зөвшөөрөхгүй, нэг тийшээ явах хэрэгтэй болно, төвхнөх хэрэгтэй болно, түүн шиг хүний хувьд энэ бүхэн чинь амаргүй, Соня, чи юмыг бодитой хар л даа. Саша одоо бол Сибирьт сарын 20 рублиэр болгоод байна. Наашлахаар чинь хэд дахин үнэтэй газар л очих болно. Сашад мөнгө хэрэгтэй, мөнгөгүй бол балрана.

-За, яахав, тэгвэл тэр мөнгө чиний хадгаламжинд байж байг, Сашад хэрэг болсон тухайд нь явуулж байя гэж Софья Александровна зөвшөөрөв. -Тэгж ярих юм бол тэд нар л миний хүүг шоронд хийж цөлсөн, одоо тэд нар л хот дамжуулан хөөнө, тийм учраас тэд нар өөрсдийнхөө мөнгөөр туслаг.

-Соня! Чи яах гэж ингэдэг юм бэ? Марк түүнийг суулгасан юм уу?

-Тэгсэн, Марк л суулгасан. Марк биш юм гэхэд Марк шиг этгээд. Тэд бүгдээрээ адилхан, яг дүндээ дүн. Дүү юу? Дүү мөн. Гэхдээ би түүнийг заяа нь уучлахгүй. Сашагаас болж ч тэгж

байгаа юм биш. Тэд Орос орныг яаж байна? Хүмүүсийг юу болгож байна? Чиний тэр Марк өөрөө юу болж хувирчихаад байна?! Хумсын чинээ ч хүнлэг юм түүнд үлдээгүй. Зүгээр л ган, ширэм хийдэг машин.

-Соня, чи дэндүүлж байна. Чи хайрт эгч нь. Саша бас түүний хайртай зээ...

Софья Александровна дүүгийнхээ үгийг тасдав.

-Тэр цаг өнгөрсөн. Одоо ганцхан хүнд хайртай, тэр нь Сталин. Энэ нэрэнд гялбаад цөмөөрөө юу ч харахаа больж. Тэдний хувьд Сталин бурхан, бурхнаас ч илүү байх, яагаад гэвэл бурханд сүсэглэдэг хүнд сайн муу, нүгэл буян, өрөвдөх хайрлах энэ тэр гэж юм байна, тэдэнд бол юу ч байхгүй. Тэдэнд зөвхөн Сталин л байна. Тэр хүн тэдний бурхан, тэдний нүнжиг.

Софья Александровна санаа алдаж,

-За, энэ тухай больё. Надад одоо ажилд орох л чухал байна гэв.

-Ажилд орох бол асуудал биш. Би хайж байна, Полина ч хайж байгаа, манай хоёр нөхөр ч ялгаагүй таних мэдэх хүмүүсээс сураглаж байна, юм олдоно.

Харин хамгийн боломжийн, хамгийн сайн зөвлөлгөөг Маргарита Артемовна гэгч хөршийнх нь ухаанлаг армян эмгэн өгчээ.

-Софья Александровна, та хаагуур ч ажил хайхын хэрэггүй, байшингийнхаа хэдэн хүүхдийг асар гэж тэр авгай хэлжээ. -Энэ Гуровынх хоюулаа ажилтай, тань шиг Соня нэртэй, таван настай их сайн охин бий, түүнийгээ харуулах хүн байхгүй, хүн хайж байгаа. Дараа нь Фортунатовынх байна, бас хоюулаа ажилтай, тэдний хүү Боря, дөрөвтэй. Цааш нь. Зоя Васильевна Величкина яах учраа олохгүй байгаа. Гуравдугаар орцны Зоя Васильевна Величкинаг мэдэх үү? Нөхөр нь ноднин нас барсан.

-Мэднэ.

-За тэр чинь эмч хүн, бүүр Сокольникийн тэр рүү ажилладаг юм. Хүүхдээ талийгаач нөхрийнхөө ажиллаж байсан “Серп и молот” (Алх, хадуур) үйлдвэрийн хүүхдийн цэцэрлэг рүү зөөнө. Мөн ч их явна аа даа? Бараг л өглөөний таван цагт босно. Тэр бол танаар хүүхдээ дуртай харуулна даа. За бас зураач Любовь Михайловна Сапожникова байна, нөхөр нь ажилдаа явчихна, өөрөө гэртээ зурна, удирдагчдын хөргийг олшруулж зурдаг юм, гэтэл хүүхдийг нь зугаа-цуулах, салхинд гаргах хүн байхгүй. За ингээд лав дөрвөн хүүхэд болчихлоо. Би мэдэхгүй, гэхдээ хэн нь ч гэсэн 25 рубль төлөх бололцоотой, ингээд бодвол 100 рубль болчихож байна. Хүүхдүүдтэй байрныхаа арын хашаанд сууж байхгүй юу. Модтой, чимээ анир байхгүй. Тэнгэр муухай байвал ээлжлээд хэн нэгнийд нь байгаад байж болно. Ер нь Гуровынх бол хоёр өрөөтэй тусдаа байртай.

-Харин ээ, сайн мэдэхгүй л байна гэж Софья Александровна эргэлзэв. -Хүүхдүүдийг хооллож ундлах хэрэгтэй, хаана тэгэх вэ?

-Тэр мэтийг зохицуулж болно. Эцэг, эх нь хоорондоо тохирно биз. Та хараарай, хүүхдээ харуулах гэсэн өөр хүн ч гараад ирнэ.

-Үгүй ээ, дөрвөөс илүү хэрэггүй, би тараагаад алдчихна.

-Нээрэн тийм шүү, дөрөв хангалттай гэж Маргарита Артемовна санал нийлэв.

Софья Александровна хоёр сар хэртэй хүүхэд харж байтал тэгсхийгээд зун болж, хүүхдийн зарим нь зусланд гарч, зарим нь хөдөө өвөө, эмээ рүүгээ явж, бүлэг нь таржээ.

Нэг удаа Софья Александровна гаднаа явж байгаад байрныхаа даргатай тааралдав. түүний нэр Виктор Иванович.

-Нөгөө хүүхдүүд чинь яасан бэ?

-Зун болчихоод ийш тийшээ тарчихсан.

Виктор Иванович бодолхийлснээ ингэж хэлэв:

-Та Левшинскийн хөндлөн гудамны 5 дугаар байшин руу оч, тэнд хөрөнгийн бүртгэлийн товчоо бий, намайг явууллаа гээд Афанасий Петрович гэдэг хүн дээр ороорой, паспортаа авч очно шүү. Тэнд түр хүн хэрэгтэй гэнэ лээ, намар болтол ажиллахгүй юү.

Хөрөнгийн бүртгэлийн товчоо Софья Александровнаг ажилд авчээ. Товчооны нэг ажилтанд байшин барилгын зураг, төсөв, бусад баримт бичгийг эмхлэх ажилд нь туслана. Софья Александровна Арбат хавийн бараг бүх байшинг мэдэх учраас ажил их ч гэсэн нөгөө талаас сонин байв. Ажлынх нь байр байшингийн зоорь ч гэсэн хуурай, тэрүүхэндээ тохилог. Цахилгаан тулга, данх энэ тэр ч бий. Үдийнхээ цайг тэндээ ууцгаана. Сард 70 рублийн цалин авна.

Варя гэртээ иртэл нэг захиа ирчихсэн байв.

Яах аргагүй танил бичиг, дугтуйг нээж гарын үсгийг харвал, тэгнээ тэр, яг Игорь Владимировичийн захиа.

“Хонгорхон Варя, хэмээн Игорь Владимирович эхлэжээ. -Би танд захиа бичиж зүрхлэхгүй байсан юм. Цэцэгний тухай Таны бяцхан захиа надад зүрхлэх эрх олгож байна. Захидлаар харилцахыг

Танд тулгасан гэж би өөрийгөө зүхэх явдалгүй боллоо. Би Танд хариулж байгаа юм чинь. Би ийнхүү бичихэд Та ялыгү ч гэсэн над руу ойртох шиг болж аятайхан байх юм.

Таны бяцхан захиаг нэлээн хэд дахиж уншлаа. Бидний хооронд бичигдсэн анхны захиа учраас үг болгоныг ойлгох гэж хичээж, янз бүрээр бодож үзэж, далд санаа байгаа эсэхийг хайж байна. Заримдаа аль нэг үгнээс өөриймсөг дотно амьсгаа мэдрэгдэх шиг болно, гэтэл таны төлөв зан санаанд орж, Та егөөдөж байх шиг санагдах юм. Таны дууны өнгийг сонсолгүйгээр Таныг юу гэж ойлгохоо мэдэхгүй байна.

Миний даруухан бэлэг Танд ямар нэг төвөг удсан бол өршөөгөөрэй, дахиад тэгэхгүй. Ёслол төгөлдөр амлаж байна.

“Утасд л даа” гэж трамвайны гишгүүр дээрээс Таны хэлснийг би мартаж чаддаггүй юм.

Танихгүй хүний хувьд тэр “утасд л даа” бол ахиулж танилцахыг зөвшөөрсөн үг. Таныг мэдэх миний хувьд бол тэр “утасд л даа” чинь “баяртай” гэх төдий үг байсан бөгөөд тэр “баяртайд” чинь ямар нэг баярын дохио байгаагүй.

Хэрвээ Та “утасдаарай л даа” гэж хэлсэн бол Та зөвшөөрч байгаа төдийгүй дуртай байгааг тань илэрхийлэх байсан. Тавхан үсэг, гэтэл мөн ч том ялгаа шүү.

Хаалттай Александрын цэцэрлэг рүү орж байснаа санана уу? Бөөн шалбааг. Таны шаахай. Кремлийн хана. Оймсны жижигхэн цоорхой. Манаачийн шүглийн дуу. Бид хоёрын зугталт. Урт сандлаар даруулсан хайсны хаалга. Ура!!! Бид аврагдлаа. Одоо манаачийг дооглосон ч болно.

Надад юм ярь л даа...

Та дэндүү өвөрмөц, хэцүү хүн.

Танд нэг зовлон тохиосон юм шиг санагдах юм. Таныг аргадаж тайтгаруулах юмсан. Таныг нөхөртэй байхад би Таны амьдралын тухай юу ч мэдэхгүй хэрнээ Таныг ойлгодог байсан. Танд туслахыг хүсэвч яаж туслахаа мэддэггүй байлаа.

Таныг Зоягүй дөхүүлж өгөх боломж надад олдохсон болов уу?

Таныг өвчтэй байхад би нэг удаа урьдчилж мэдэгдэлгүйгээр эргэхээр (би даргын хувьд удирдлагандаа байгаа хүмүүсийн эрүүл мэндийн талаар санаа тавих үүрэгтэй биз дээ) шийдсэн юм. Шатаар өгсөн үүдэнд чинь очоод хэсэг зогслоо. Хонх дарах гээд гараа өргөсөн чинь нэг юмнаас, магадгүй, Таныг нүүр өгөхгүй гэснээс ч юм уу, айгаад доошоо хар эрчээрээ харайлгаж буугаад гэр рүүгээ явж одсон. Би Танд энэ тухай ерөөсөө яриагүй.

Би хөгжимд дуртай, консерваторид очиж сонсдог, Тантай цуг хөгжим сонсох юмсан гэж хичнээн их хүснэ гээч.

Ийм уйтгартай захиа бичсэнийг минь өршөөгөөрэй.

Бид ажил дээрээ өдөржин нэг дор байдаг ч чухамхүү ажил л

биднийг салангид байлгаж байна. Надад Та хоёрхон үг ч гэсэн бичээрэй, цахилгаан утас шиг л байна биз, тэгвэл бид дахиад хоюулхнаа уулзсан мэт болно. Тэгээд би бас хариу бичнэ. Миний захидлууд Танд сайхан байгаасай гэж би хүсч байна.

Та тэр нэгэн удаа, анх “Националь”-д орж ирэхдээ өргөн бүрх малгайтай байсан. Малгайгаа авмагц Таны номхон тунгалаг нүд дүрлийгээд ирсэн билээ. И.В.

P.S. Энэ захиаг би бараг жилийн өмнө бичсэн боловч явуулж зүрхлэхгүй байсан юм. Одоо ганц ч үг засалгүй явууллаа, учир юун гэвэл Таныг хайрлах сэтгэл, бахдах бахархал маань өчүүхэн ч өөрчлөгдөөгүй. И.В.”

Варя захидлыг өвдөг дээр тавьж, зөндөөн удаан бодлогошрон суув. Чин сэтгэлийн сайхан захидал. Игорь Владимирович өөрөө ч сайхан хүн. түүнтэй суувал санаа зовох юмгүй, хөнгөн, хөгжилтэй, гоё амьдрах байсан байх. Тэрээр дээдсийн хүрээлэнгийн хүн, тэр хүрээлэнгийнхний эдэлдэг жаргал бүхэн түүнд хүртээлтэй. Дуулгавартай яваадаа тийм буян эдлээгүй, авьяас билгээрээ, ажил хөдөлмөрөөрөө эдлэж яваа. Энэ бол чамгүй зүйл, ердөө чамлах зүйл биш, тийм учраас өөрөө Игорь Владимировичийг хүндэтгэдэг. Гэтэл нийтийн сууцны туниагүй байдалтай жишихэд ноднинхон үлгэрийн юм шиг санагдан, даллан дуудаж байсан нөгөө амьдралыг одоо нэгэнт шохоорхохоо больсон билээ. Тэрээр энэхүү амьдрал гээч зоосны нөгөө талыг эдүгээ мэддэг болжээ. Хажууд нь өлөн өвгөд, эмгэд, хүүхэд шуухад зовж, зүдэрч, өлбөрч үхэж байхад яаж санаа зовохгүй, яаж юм бодохгүй аж төрөх юм бэ! Өлсгөлөн, худал хуурмаг явдалтай тэмцэх хүч өөрт нь байхгүй, яаж тэмцэхийг ч мэдэхгүй, гэхдээ энэ найранд орж бас наргихгүй.

Тэрээр Сашаг хүлээж байгаа... Саша өөрөө яаж аж төрөхөө ч мэднэ, түүний яаж аж төрөх ёстойг ч мэднэ! Ялангуяа энэ элдэв сорилтод өртсөний дараа бүр сайн мэднэ. мань хүнд амаргүй байх нь мэдээж, цөллөгнөөс ирсний дараа Москвад суухыг зөвшөөрөхгүй гэж хүн болгон яриад байгаа. Хаа ч аж төрлөө гэсэн өөрөө түүнд туслах үүрэгтэй. Ямар ч хүнд түшиг тулгуур хэрэгтэй. Тэгэхээр Варя өөрөө л Сашагийн түшиг тулгуур болно, түүнд өөр түшиг байхгүй!

Гэтэл тэр нэг удаа Сашагийн зурагнаас болж Нинатай хэрэлдээд хэлсэн үг нь санаанаас гарахгүй зовооно. Нина тэгэхэд “Саша сүйт хархүү чинь юм уу, тэгвэл түүнийгээ хүлээхгүй юу гээд нэг муу луйварчингаас зүүгдчихсэн юм?” гэж хашгичсан. Костятай сууж байсныг Саша бас урвалт гэж үзэх юм болов уу? Уул нь урвалт биш! Юу ч мэдэхгүй охин биеэ даасан хүн болох гэж том санаалж, хүнтэй суучихвал тийм болох юм шиг бодсон хэрэг. Тэр нь алдаа болсон. Сашад тэр тухай бичээгүй, жидүү нь хөдлөж, урам нь хугарвал хэрэггүй л дээ. Харин Сашаг эргэж ирэхээр нь өөрөө бүх үнэнийг хэлнэ, мань хүн ч бүгдийг ойлгоод Костятай холбогдсон явдлыг нь өршөөнө.

Варя Игорь Владимировичид ямар хариу өгөхөө удаан эрэгцүүлжээ. Юу гэж хариулах вэ, яаж хариулах вэ? Захиа бичих үү, шууд нүүрэн дээр нь хэлэх үү? Тэгээд шууд ярилцсан нь дээр гэж шийджээ.

Варя эвийг нь тааруулж байгаад Игорь Владимировичийн өрөөнд орлоо.

-Игорь Владимирович, би таны захианы тухайд явж байна.

түүний царай нь цайн,

-Тийм үү? гэхээс цааш гарсангүй.

-Би танд нэг юм хэлэх гэсэн юм: Би нэг хүнд хайртай, тэр маань эндээс их хол байгаа,

жилийн дараа ирнэ. Би түүнийг хүлээж байгаа.

Игорь Владимирович чимээгүй байзнаснаа сэтгэлээ барив боллохтой,

-За тэгвэл яахав, Варенька, би ч бас хүлээж байя... хэмээн эелдэгхэн инээмсэглэв.

ДЯАК-ын удирдлагаас хамгийн боловсролтой нь гэгдэх эдийн засгийн хэлтсийн дарга Мироновт гол яллагдагсад болох Зиновьев, Каменев хоёрыг гараас гаргахыг даалгажээ.

Чухамхүү Сталины саналаар түүнийг эдийн засгийн хэлтсийн дарга болгосон, Сталин ч ажлынх нь тухайд сэтгэл ханамжтай бай-даг тул үе үе Ягодын хамт дуудаж уулздаг билээ. Энэ нь ч Ягодын санаанд таардаг байж. Миронов ой сайтай, Сталинаас буцаж ирэнгүүт түүний ярьсныг нэгд нэгэнгүй цаасан дээр буулгачихна. Сталины даалгаврыг нүүрэн дээр нь тэмдэглэж авах нь тэр болгон зохисгүй, Зиновьев, Каменев хоёрыг шүүх асуудлаар бол тэмдэглэл хийж ерөөсөө болохгүй. Учир юун гэвэл, Сталин энэ ажлыг Улс төрийн Товчооны гишүүдээс ч далдуур нууц удирдаж байгаа юм. Товчооны гишүүд энэ тухай шүүн таслах ажиллагааны бэлтгэл бүрэн дууссан хойно сая сонссон болой.

Миронов ажлаасаа халагдах гэж байгаа тухай яриа бий. Зарим нь Ягода түүнийг өрсөлдөгч гэж үзэж зайлуулах арга хийж байна гэцгээх, зарим нь Миронов эдийн засагч учраас Гадаад худалдааны ардын комиссариатад ажиллах санаатай гэцгээх. Мироновтой найзладаг Вутковскийн цухуйлгасан үгнээс цаадах нь ахмад большевикуудыг шүүх ажиллагааны бэлтгэлийг хангалцах дургүй байгааг Шарок ойлгожээ. Вутковский өөрөө ч гэсэн энэ ажилд их хойрго оролцож буйг Шарок тодоос тод харж байгаа билээ.

Араар тавьдаг Слуцкий, бүдүүлэг хэрцгий Гай энэ тэрийг бодвол Миронов уян зөөлөн хүн гэгддэг аж. Нөгөөтэйгүүр мань хүн энэ ёозгүй ажлыг үнэхээр намын эрх ашгийн үүднээс хийж байгаа гэж бат итгэнэ. Тэрээр хорлон сүйтгэгчид гэгчдийг мөрдөж байсан, харин намын дотоод харьцаанаас үүдэлтэй хэргийг мөрдөхөд оролцож яваагүй, хуучин намын гишүүн явсан хүмүүсийг баривчлах, цөлөх зэрэгт огт хавирч байгаагүй. Троцкийчууд, зиновьевчууд, бухаринчуудтай ажиллах туршлага мань хүнд байхгүй, гэтэл ингээд шууд Каменев дээр буучихдаг байна. Лениний дотнын анд, журмын нөхөр, Улс төрийн Товчооны гишүүн асан Каменев шүү дээ. Хурал цуглаан дээр үгийг нь хичнээн удаа бахархан сонсож, яаж алгаа халуун оргитол ташиж байлаа даа. Тэрхүү Каменевыг одоо өрөөнд нь оруулаад ирсэн, мань Миронов түүнийг байцаах ёстой, Каменев алан хядагч үзэлтэн, алуурч гэдгийг түүгээр хүлээлгэх ёстой болж байна.

Миронов сандал руу зааж суулгаад,

-Иргэн Каменев! хэмээн эхлэв. -Сөрөг хүчний хэд хэдэн хүн 1932 оноос эхлэн таны удирлагын дор нөхөр Сталин, Улс төрийн Товчооны бусад гишүүдийг алахаар бэлтгэж байсан, тухайлбал, нөхөр Кировыг алсан гэсэн мэдүүлэг таны хэрэгт байна.

-Энэ тийм биш гэдгийг та сайн мэдэж байгаа. Большевикууд хувь хүнийг устгах аргыг хэзээ ч хэрэглэж байгаагүй гэж Каменев хариулав.

Миронов Рейнгольдын мэдүүлгийг түүнд уншиж өгөв.

-Наана чинь ганц ч үнэн үг алга.

-Нүүрэлдүүлвэл Рейнгольд энэ бүхнийг нотлоно.

-Тэг л дээ.

Нүүрэлдэх уулзалт дээр Рейнгольд, Каменевын гэрт алан хядах үйлдлийн бэлтгэлийн талаар хэлэлцэж байхад нэг бус удаа тэнд байснаа нотлов.

-Та манайд чухам хэзээ очиж байсан юм бол?

-Хэзээ гэдгийг та өөрөө сайн мэдэж байгаа! Өдөөн хатгасан асуулт битгий тавиад байгаарай.

Каменев хууль ёсоо дагахыг уриалсан харцаар Миронов руу харав.

-Иргэн Рейнгольд, иргэн Каменев ийм асуулт тавих эрхтэй гэж Миронов хэлэв.

Рейнгольд дал мөрөө хавчин,

-Би 1932, 33, 34 онд хэд хэдэн удаа очсон гэж, миний бодлоор бол, тов тодорхой хэлсэн гэв.

-Тэгвэл та манай гэрийн өрөөнүүдийн байрлалыг аль болохоор тодорхой хэлж өгөхгүй юу гэж Каменев хүсэв.

Рейнгольд баригдсанаа ойлгонгуут бүдүүлэг авирлаж эхлэв.

-Ийм асуултад би хариулах албагүй. Танай байр дурсгалын

музей хараахан болчихоогүй байх, болох нь ч юу л бол, би танайд экскурсээр очоогүй, байрыг чинь сонирхоогүй.

Каменев Мироновг хандаж,

-Нөхөр Миронов, та энэ тухай иргэн Рейнгольдоос лавлаж өгөхгүйсэн болов уу? гэв.

Рейнгольдын баригдсаныг Миронов ч бас ойлгожээ.

-Иргэн Каменев, энд танай байрны тухай яригдаагүй, таны иргэн Рейнгольдтой ярьсан зүйлийн тухай л яригдаж байна.

-Ямар ч атугай иргэн Рейнгольд миний асуултад хариулахаас зайлсхийснийг протоколд тэмдэглэж өгөхийг хүсье гэж Каменев шаардав.

-Би протокол хөтлөхгүй байна шүү дээ, энэ бол урьдчилсан яриа. Бид яриагаа цаашид үргэлжлүүлнэ.

Үүгээр нүүрэлдэх уулзалт дуусч Каменев Рейнгольд хоёрыг өрөө өрөө рүү нь аваад явжээ.

Миронов тэр даруй Шарокийг утсаар дуудав.

Шарок ирлээ.

-Нөхөр Шарок, та Рейнгольдыг бэлтгэсэн, муу бэлтгэсэн байна.

Шарок гайхаш тасарсан харцаар Мироновыг харав. Рейнголь-дын мэдүүлэг бишдвэл яллагааны бүх ажил нурж, хамаг бурууг нь, мэдээж, өөр рүү нь чихнэ гэж бодохоос мань Шарокийн зүрх зогсчих шиг болов.

-Каменевын гэрт очиж байсан гэж түүний мэдүүлэгт нэг бус удаа дурдсан байна. Гэтэл нүүрэлдүүлсэн чинь Рейнгольд өрөөнийх нь байрлалыг хүртэл мэдэхгүй байгаа нь илэрлээ. Та үүнийг урьдаас харах ёстой байсан. Үгүйдээн, нэг ч удаа болохноо Рейнгольдыг Каменевын гэрт аваачиж үзүүлэх хэрэгтэй байсан юм.

Шарокийн дотор уужрав. Миронов, мэдээж, том дарга. Гэхдээ том дарга, сайн мөрдөгч хоёр бол өөр өөр зүйл. Мөрдүүлж байгаа хүнийг нугалж авах-нэг хэрэг, түүнийг нүүрэлдэх уулзалтад бэлтгэх -шал өөр хэрэг. Рейнгольд олон хүний тухай мэдүүлэг өгсөн, түүнийг тэдний гэр орноор чирч явах боломж Шарокт байхгүй, ер нь тэгж явахыг хэн ч зөвшөөрөхгүй. Рейнгольдыг чухамхүү Каменевтай нүүрэлдэх уулзалт хийхэд б э л т г э х хэрэгтэй гэдгийг Миронов Шарокт урьдчилан хэлбэл зохих байсан. Хэрэв тэгсэн бол Шарок бүх юмыг шалгаж, ямар ч өөлөх баалах юмгүй бэлтгэлгүй яахав. Тэгээгүй учраас энэ бол Мироновын алдаа.

Шарок энэ бүхнийг эелдэг даруу байдлаар Мироновт тайлбар-лав. Цаадах нь ухаантай хүн учраас хий гаргаснаа ойлгожээ.

Шарок ч бас ухаантай. Молчановын өрөөнд болсон мөрдөх хэсгүүдийн зөвлөлгөөн дээр Миронов Каменев ямар ч мэдүүлэг өгөхгүй, үр дүн гарахгүй байгаа, нүүрэлдүүлэх уулзалт ч нэмэр болоогүйг илтгэхэд, нүүрэлдэх уулзалтыг зохих ёсоор бэлтгээгүй

тухай Шарок ганц ч үг ганхийсэнгүй. Миронов түүн рүү нэгэнтээ харснаас өөрт нь үнэнч, хүлээцтэй хандаж буйг нь үнэлж буйг Шарок ойлгов. түүнээс гадна Каменевыг байцаагаад нэмэргүй, тийм учраас Рейнгольдын адил түүнийг Ежовт шилжүүлэх санал Миронов Ягодад тавьсныг Шарок Вутковскийгээс олж мэдчихээд байсан билээ.

Гэвч Ягода Ежовоос туслалцаа авахыг энэ удаа ч бас хориглож, өөрийнх нь гэрээр олонтаа орж гардаг, түүний гарын хүн Черто-кийг Каменевыг мөрдөн байцаах ажилд татан оролцуулахыг үүрэг болгожээ.

Шарокийн өрөө Чертокийнхтэй нэг хонгилд байдаг болохоор үүдээр нь гарахад Каменевыг байцааж байгаа нь тодхон сонсдоно.

-Чи бол хулчгар урвагч, Ленин чамайг тэгж хэлж байсан хэмээн Черток хашгична. -Нөхөр Сталин нууц байдалд тэмцэж байхад чи Парисын гуанзанд кофе уугаад сууж байсан. Чи бүх насаараа нам, ард түмэн, ажилчин ангийн хүзүүн дээр сууж байна. Муу хачиг, хувалз! Чи Кировыг алсан, чи намын бүх гишүүнийг алахаас буцахгүй. Чамайг одоо гудамжинд гаргалаа гэхэд анхны таарсан хүмүүс л чамай мууг өмхий бясaa шиг няц нитгэрнэ. Зиновьев та хоёрыг

Үйлдвэрт аваачих юм бол буцааж цуглуулахын аргагүй болтол тасчиж хаяна. Чи бол новш, баас! Чи бол нэгэнт дууссан этгээд, би тушаалаа л бол чамайг арван минутын дотор гудрага шиг буудаж ална, тэглээ гэхэд хүмүүс надад баярлалаа л гэж хэлнэ. Чамай мууг яахав гэж харж үзээд утсан чинээ улаан голыг чинь хэлтрүүлнэ гэж баталгаа өгч байхад чи муу баас эргэлзэнэ гэнэ ээ! Номхон зогс, муу хүний адаг, бүү хөдөл!

Черток Каменевыг ийнхүү зүхэж, буухиачлан байцааж олон удаа унаж ойчихыг нь харсан боловч, Тэрээр юу ч олж долоосонгүй, Каменев ямар ч мэдүүлэг өгсөнгүй.

Каменев дээр бүдэрсэн, Смирновыг нугалсан ч цаанаа эргэлзээ-тэй байгаа зэргийг харгалзан мөрдлөгийн ажлыг Ежов гартаа авчээ. Сталин яаруулж байсан учраас Ягода эсэргүүцэж чадсангүй. Мөрдлөгийг цааш нь удаашруулбал Ягодад өөрт нь ч муугаар дуусч мэднэ. Харин одоо бол бүх хариуцлага Ежовт оногдоно.

Каменев, Смирнов хоёртой ажилласан туршлагаас үндэслэн Ежов шууд шинэ тактик хэрэглэж, Троцкийн нэрийг гутаахад шаардлагатай мэдүүлэг өгөхийг Улс төрийн Товчооны нэрийг барьж Зиновьевоос шаарджээ.

Бие өвчтэй, хөл дээрээ тогтож ядсан Зиновьевыг шөнө Аграновын өрөөнд авчрав. Тэнд Ежов тэр хоёроос гадна Молчанов, Миронов нар байлцав. Ежов Мироновт дэлгэрэнгүй протокол хөтлөх үүрэг өгчээ. Ягода Ежовын дэргэд өөрийгөө жижгэрүүлэхийг хүсээгүй учир шалтаг заан ийшээ ирээгүй бөгөөд Ежовыг алдаа гаргаж магадгүй гэж дотроо горьдон үйл ажиллагааг нь хардан ажиглаж байгаа аж.

Ежов зөвхөн Сталины үүрэг даалгаврыг бичиж авдаг том дэвтэр рүүгээ зогсоо чөлөөгүй шагайн байж Япон, Герман хоёр 1937 оны хавар ЗСБНХУ руу довтлох гэж байгаа тухай ямар ч мадаггүй мэдээ бий. Тийм учраас одоо ЗСБНХУ-д олон улсын пролетарийн дэмжлэг онцгой хэрэгтэй байна. Гэтэл энэ дэмжлэгийн зам дээр Троцкий хаалт болон зогсож байна. Тиймээс Троцкий болон түүний балмад байгууллагуудын үнэн нүүрийг бүрмөсөн илчлэхэд Зиновьев намдаа туслана гэж Улс төрийн Товчоо найдаж байна. Хэрвээ Зиновьев үүнийг ёсоор болговол намын эсрэг тэмцлээ эцсийн эцэст бүрмөсөн зогсоосноо нотлох болно гэж айлдав.

-Надаас тодорхой юу хүсч байгаа юм бэ? гэж Зиновьев амьсгаа нь давхцан асуув.

-Шүүн таслах ил хуралдаан дээр та Троцкийн даалгавраар Сталин, Улс төрийн Товчооны бусад гишүүдийг алах бэлтгэлийг үзэл бодол нэгтнийхээ хамт хийж байсан, нэг тийм аллагыг хэрэгжүүлж нөхөр Кировыг алсан гэдгээ хүлээх ёстой.

-Би хэзээ ч ийм юм хийхгүй, тийм худал хуурмаг зүйл та нар надаар хэлүүлж чадахгүй.

-За, яахав гээд Ежов дахиад дэвтэрээ шагайв. -Танд нөхөр Сталины үгийг уламжлая: “Хэрэв Зиновьев хэрэг хүлээвэл түүний амь насыг хэлтрүүлнэ. Татгалзвал түүнийг болон сөрөг хүчний бүх хүнийг цэргийн хаалттай шүүхээр шүүнэ”.

-Та нарт миний толгой хэрэгтэй байх нь. За яахав, миний толгойг Сталинд царан дээр өргөн бариарай гэж Зиновьев аяархан өгүүлэв.

-Тэгвэл та сөрөг хүчний мянга мянган хүний амь насаар дэнчин тавьж байна, тэдний амь нас таны гарт байна шүү.

-Би юу гэж ч мэдүүлсэн, ямар ч цаасан дээр гарын үсэг зурсан та нар намайг алдгаараа ална, дээр нь мянга мянган хүнийг ална, Лениний үеийн бүх журамт нөхдийг хөнөөнө гээд Зиновьев амсхийж хүчээ сэлбэснээ, -Та нар надаар юу ч хэлүүлж чадахгүй гэдгийг давтан хэлье хэмээн эрс шийдэмгий өгүүлэв.

Ежов Зиновьевыг буцааж аваачих, Каменевыг нэн даруй авчрах тушаал буулгав. Тэрээр заавал амжилт олох ёстой байсан, тэр санаандаа хөтлөгдөөд, Чертокийн “гараар орсон” Каменев эрхбиш дуулгавартай байх биз гэж тооцоолсон бололтой. Гэхдээ бүрэн итгэхгүй байсан тул илүү гэрч нарын өмнө дахин нэг ялагдал хүлээхээс болгоомжлон, Каменевыг мөрдсөн Мироновыг үлдээж, Агранов Молчанов хоёрыг явуулав.

Ежов Зиновьевт ярьсан зүйлээ Каменевт давтав. Харин төгсгөлд нь, Рейнгольд Каменевын хүүтэй хамт Дорогомиловын гудамжинд Сталин, Ворошилов хоёрын машиныг отож байсан тухай Рейн-гольдын мэдүүлэг мөрдлөгийнхөнд байгаа гэж мэдэгджээ.

-Алма-Ата руу цөлөгдөөд жил хагас болж байгаа миний хүү тэр гудамжинд яаж очсон нь сонин байна?

-Та хүү Александрыгаа хэлж байна, Рейнгольд танай нөгөө хүү Юрийг мэдүүлсэн байгаа, үүнийг унш даа гээд Ежов Рейнгольдын мэдүүлгийг түүн рүү сарвайв.

Каменев түүнийг уншаад,

-Энэ... Энэ чинь... Юра чинь ердөө пионер шүү дээ гэж балмагдан гүвтнэв.

-Та ЗСБНХУ-ын ТГХ, АКЗ-ийн 1935 оны дөрөвдүгээр сарын 7-ны өдрийн тогтоолыг мэднэ биз дээ? Эсвэл та түүнийг мартсан юм болов уу? Тэгвэл сануулж өгье: “Хулгай хийсэн, бусдыг хүчирхийлсэн, бие махбодид нь гэмтэл учруулсан, өрөөл татанхай болгосон, алсан буюу алах оролдлого хийсэн зэрэг нь илчлэгдсэн 12-оос дээш насны насанд хүрээгүйчүүдийг эрүүгийн ялын бүх төрлийг хэрэглэхээр эрүүгийн шүүхэд татаж байсугай”. Нөхөр Калинин, нөхөр Молотов, нөхөр Акулов нар гарын үсэг зурсан тогтоол. Ийм байна. Танай хүү 12 наснаас өнгөрсөн. Тэгэхээр нөхөр Сталин, Ворошилов нарын амь насанд халдах оролдлого хийсэн түүнд зохих ял, өөрөөр хэлбэл, ялын дээд хэмжээ оногдоно.

-Чи үл бүтэх этгээд! Өөдгүй амьтан! гэж Каменев хашгирав.

Ежов утсаа авч Каменевын хүү Юрий Каменевыг нэн даруй баривчилж, “троцкийчууд-зиновьевчуудын алан хядах төв”-ийг шүүн таслах ажиллагаанд түүнийг хамруулахаар бэлтгэх үүргийг Молчановт өгөв. Ийм шийдвэр өгчихөөд Каменев руу харах ч үгүй өрөөнөөсөө гарч одов.

Каменевыг өрөөнд нь буцааж авчрав.

Тэрээр цаашдаа юу болохыг мэдэж буйн зэрэгцээ өөрт нь тус болох юм юу ч байхгүйг ойлгож байлаа.

1935 оны нэгдүгээр сарын шившигт шүүх хурал дээр Каменев Кировыг алсны ёс суртахууны хариуцлагыг намын эрхэм дээд эрх ашгийг бодож хүлээсэн. түүнийхээ төлөө таван жилийн хорих ял авсан. 1935 оны долдугаар сард дүүгийнх нь авгай, засгийн газрын номын сангийн ажилтан Нина Александровнагийн оролцсон гэх Кремлийн хуйвалдаан гэгч домогтой холбон түүнийг дахиад хаалттай шүүх хурлаар оруулсан. Дүүг нь авгайнх нь хамт яланд унагаад, Каменевт өөрт нь арван жилийн ял өгсөн.

түүний анхны авгай Ольга Давыдовнаг 1935 оны гуравдугаар сард Ташкент руу цөлсөн. Жуковскийн нэрэмжит цэргийн нисэх хүчний академи төгссөн том хүү Александрыг нь мөн гуравдугаар сард Алма-Ата руу цөлсөн.

түүний хоёрдахь авгай Татьяна Ивановна Глебова, дагавар хүү Игорь, Каменевтай суугаад гаргасан таван настай хүү Владимирын хамт Дундад Ази руу цөлөгджээ. Чухамхүү Глебовагийн Арбатад, Карманицкийн гудманд байдаг байрнаас Каменевыг 1934 оны арван хоёрдугаар сарын 16-нд анх баривчилсан билээ.

Бага хүү Юрий, таван настай ач хүү Виталий хоёр л баривч-лагдаагүй үлдсэн юм.

Тэгтэл одоо Юрад тэдний савар хүрч, пионер хүүхдийг алан хядагч хэмээн буудан алахыг зорьж байна. Долоон жилийн дараа Виталийг 12 нас хүрмэгц нь оролдож эхлэнэ. Золгүй хүүхдүүд.

Каменев захныхаа товчийг тайлав. Тэдний өрөөнд нар ерөөсөө тусдаггүй, долдугаар сард хүртэл нэлээн сэрүүхэн байдаг атал өнөөдөр лут халуун өдөр бололтой.

мань хүн шүүх хурал дээр гарсан ч, гараагүй ч ялгаа байхгүй буудан алуулна гэдгээ сайтар ойлгож байв. Аль ч тохиолдолд ард түмний нүдэнд алан хядагч, тагнуул, эсэргүү болж хоцроно. Цаадуул нь энэ зэргийн юмыг чадна. Харин хуурамч мэдүүлэг өгч гүжир яллагыг баталгаажуулбал хүүхдүүдийг нь өршөөж магадгүй. Өөрт нь ингэх эрх бий юү? Өөрийнх нь нэр төр, ямар ч гэм буруугүй хүүхдүүдийнх нь амь нас хоёрын аль нь үнэтэй вэ? Гэтэл нэр төрөө нэгэнт алдсан биш үү. Байнга гэмшиж, алдаа дутагдлаа хүлээж, Сталиныг магтан сайшааж ирсэн энэ хэдэн жилд нэр төрөө нэгэнт алдсан. Нийтийн өмнө өөрийгөө дахин нэг гүтгэлээ гэхэд нөгөө гутамшигт жагсаалтад юу нэмэгдэх юм бэ? Юу ч нэмэгдэхгүй. Ямар ч тохиолдолд урвагч, тэрслэгч, тагнуул, зөвлөлтийн эсрэг үзэлтэн гэсэн им тамгатай үлдэнэ. Тэглээ ч гэсэн, тэглээ ч гэсэн...

Халуун тэсэхийн аргагүй болж ирэв. Юу болчихов оо? Тэрээр халаалгын батарейнд гараа хүргэнгүүт татаж авлаа. Золтой л түлчихсэнгүй. хүний шаарнууд, үл бүтэх новшнууд! Өрөөг нь тэсэхийн аргагүй халуун болгож байж түүнийг буулгаж авахаар шийдсэн байх нь.

Тэрээр хаалгаа тогшив. Дахиад тогшлоо. Шагайвч нээгдэж,

-Юу хэрэгтэйв? гэж хянагч асуув.

-Яагаад халаагаад байна вэ?

-Тэр маний мэддэг ажил биш!

Шагайвч торхийн хаагдлаа.

Эсэргүүцээд нэмэргүй. Эсэргүүцэх тусам улам халаана, улам шатаана.

Үгүй ээ, тэдэнд заяа нь бууж өгөхгүй. Кобагийн бахыг тэгэж хангахгүй. Тэрээр арван жилийн өмнө, 1927 онд бол мань Кобад буулт хийсэн бус, насласан 53 жилийнхээ 35-ыг зориулсан намдаа л буулт хийсэн. Лениний анд, журмын нөхөр, ленинч Улс төрийн Товчооны завсаргүй гишүүн, Бүх Оросын Төвийн Гүйцэтгэх Хороо-ны анхны дарга хүн чинь одоо болохоор өөрийгөө алан хядагч, тагнуул, зөвлөлтийн эсрэг үзэлтэн гэж хүлээн зөвшөөрөх ёстой гэнэ. Ийм буулт намд хэрэггүй, ийм золиос намд хэрэггүй, ингэж хүлээн зөвшөөрөх нь намд ашиггүй төдийгүй харин ч хор хүргэнэ, энэ бол Лениний нэрийг гутаах, түүний тойрон хүрээлэгчид, түүний журмын нөхдийг гутаахад Сталинд л хэрэгтэй. Тэгэхээр коммунист чигээрээ үхье гэж байгаа бол, энэ яваа насаа, үгүй ядахдаа ө ө р и й н х ө ө х у в ь д нэр төртэй дуусгая гэж байгаа бол мань хүн шүүх хуралд оролцох ёсгүй, худлаа мэдүүлэг өгөх ёсгүй. Сталин түүнээс өшөөгөө авч, хүүхдүүдийг нь хөнөөнө, тэгвэл тэгэг, тэр бүхнийг намдаа өргөсөн өргөл болгоно. мань хүн мөрдлөгийнхний тулгалтыг хүлээн зөвшөөрлөө ч гэсэн, Сталины шаардлагыг биелүүллээ ч гэсэн Сталин түүнийг алдгаараа ална, хүүхэд төдийгүй ачийг нь ч ална, тэр бол үр удмыг нь нэгмөсөн тасартал тооцоо хийдэг хүн.

Тэрээр өмд, цамц, оймсоо тайлж, бохир майк, шуудагтайгаа цементэн шалан дээр хэвтэж үзсэнд амьсгаа авахад арай дээрдэв.

Хаалганы шагайвч нээгдлээ.

-Хоригдол, бос!

Каменев хөдөлсөнгүй.

Шагайвч хаагдлаа.

Төдөлгүй хөлийн чимээ гарч, хаалга нээгдэн гурван мангар харгалзагч орж ирэв. Нэг нь сандал барьчихаж.

Тэд нар Каменевыг босгож, сандал дээр суулгаад олсоор сандалтай нь хүлэв.

-Муу бэлтрэг, ингээд сууж бай!

Цагаан халаадтай эмч орж ирээд, судсыг нь барьж, зовхийг нь сөхөж нүд рүү нь харснаа хүлээсний чанга сулыг татаж үзчихээд гараад явчихав.

Харгалзагчид ч араас нь гарцгаалаа.

Лев Борисович амьсгалж чадахаа болив. Сандлыг яг батарейны хажууд тавсныг хэлэх үү.

Хүлээстэй гар хөл нь чилж мэдээ алдаж байна. Одоо хэр ухаан алдаагүй ч толгой нь цээж рүүгээ гудайн унжлаа. Тэгсхийгээд мансууран, тун сая юу бодож, нүдэнд нь юу эрээлжилж байсныг санахаа болих шиг ч.

Хаалга дахин нээгдэж, харгалзагч дагасан эмч орж ирээд, дахин судсыг барьж, нүдийг нь нээж үзсэнээ,

-Үргэлжлүүлж болно гэж өгүүлэв.

Хагас жил өнгөрчихөөд байхад Альтман ер утасддаггүй.

Шарок түүнд хэдэн үг хэлсэн нь гарцаагүй, тэгээд л Альтман мань эрийг мөрөөр нь орхиоор шийдсэн байж таарна. Тэд нарт ч өөрийн гэсэн нөхөр ёсны эв санааны нэгдэл байгаа нь лав, нэг нөхөр нь гуйж байхад харж үзэх хэрэгтэй, хэрэг гарвал өөрийнх нь хүсэлтийг ч нөгөөх нь харж үзнэ.

Юрка эр хүн!

Дэндүү эмзэг асуудал учраас Вадим Юрад юу гэж утасдах вэ. Харин Арбатын тэнд нэг удаа тааралдахдаа гарыг нь чанга атган малилзаж, талбай хүртэл дөхүүлж өгөөд салахдаа,

-Баярлалаа, Юра! гэж л хэлсэн.

Юра хариуд нь инээмсэглэсэн боловч юу ч хэлэлгүй трамвайдаа ороод гар даллан оджээ. Вадим хэзээний дүйрэн байсан, дүйрэн чигээрээ л явна. Юра түүний асуудлыг хөөцөлдөнө гэж үнэхээр найдлаа гэж үү? Т и й м явдал дээр хэн ч хэний ч асуудлыг хөөцөлддөггүйг үнэхээр ойлгохгүй байна гэж үү? Энэ сэхээтнүүд хүний элэг авах улс шүү. Альтман мөрдлөгийн нэг хэсгийн бүрэлдэхүүнд орж, шүүн таслах ажиллагааны бэлтгэлд оролцож байгаа учраас л түүнийг дуудахгүй байгаа билээ. Юун Вадимтай мантай. Шарокийн хувьд гэвэл Вадимын хэргийн тухай бодох ч хүсэлгүй байжээ. Харин Викагийн хавтаст хэргийг гадаад хэлтсийнхэн сонирхож эхэлснийг баримжаагаар гадарлажээ.

Гэвч Вадим энэ бүхнийг эс мэднэ. Шарокийн найрсаг дүрийг харчихаад нэгмөсөн тайвширчээ.

Тэрээр улам их юм бичдэг болсон төдийгүй түүнээсээ ч их яриа хийдэг болж нэр цуу нь түгсээр байв. түүнтэй танилцах гэсэн хүний тоо ч олширсоор.

Нэг удаа Ершилов Саратовоос ирсэн ачдаа Москвагийн алдартнуудыг харуулахаар Зохиолчдын клубт дагуулж иржээ. Вадимтай тааралдаад Ершилов ачийгаа танилцуулав.

-Төмөр замд ажилтай хүн, гэхдээ театрын яггүй хорхойтон. Чиний Коонентой хийсэн ярилцлагыг уншсанаас хойш Их театр, Мейерхольд энэ тэрийн аль нь ч хэрэггүй болж, гагцхүү Камерын театрт орно гээд зүтгэчихсэн. Байдал иймэрхүү байгаа, зөв үү?

Нөгөө залуу толгой дохилоо.

-Тэр асуудал биш. Зарлал харж, жүжгээ сонгочихоод над руу утасдаарай гэж Вадим хариулжээ.

Ершилов нохойтож зулгуйдаж байна. Гэхдээ тэр ярилцлага улс орноор тэгж түгсэнийг мэдэж авахад өөрт нь аятайхан байж. Саратовт хүртэл уншсан байх нь. Чухамдаа тэр ярилцлага бол түүний анхны нухацтай ажил. Гучин дөрвөн оны яг эцсээр, жил хагасын өмнө бичсэн юм.

Гучин дөрвөн оны сүүлээр Камерын театрын хорин жилийн ой тохиосон, гэхдээ ойн баярыг нэгдүгээр сарын эхээр тэмдэглэхээр хойшлуулсан билээ. Тэр үед Вадим нэг чухал юм хийхсэн, жишээлбэл, ардын жүжигчин болох гэж байгаа Алиса Коонентай дэлгэрэнгүй ярилцлага хийж сонинд шургуулах юмсан гэж хорхойсч байжээ. Таиров, Коонен хоёрт тийм цол олгох тогтоол бэлэн болчихсон, бараг гарын үсэг зурагдчихсан гэдгийг хэн хүнгүй мэдэж байсан цаг. Тогтоол нийтлэгдэхийн яг өмнөхөн тийм тиймэрхүү юм өөш шиг хаяж өгвөл мөн догь оо.

Гэвч Коонен ярилцлага өгөхгүй, ойртох гэж оролдохын ч хэрэггүй зав чөлөөгүй байгаа.

Гэтэл эцэг нь туслахаар болж,

-Алиса Георгиевна надад хэзээ ч үгүй гэхгүй хэмээжээ.

Үнэхээр ч үгүй гэсэнгүй, зөвхөн “Юун яаруу, давчуу юм бэ дээ?” гэж гайхасхийснээ утсаа тавилгүй цагийн хуваариа харж байгаад, арван хоёрдугаар сарын 26-нд яг дөрөв арван тавд гэртээ ир гэж болзоо товложээ.

Цөөхөн хоног үлдсэнийг хэлэх үү, бэлтгэлээ сайн хангах шаардлагатайг хэлэх үү, Вадим ажилдаа ханцуй шамлан орлоо...

Камерын театрын гол бүтээл нь “Бадрангуй эмгэнэл”, дээхнэ үед тоглож байгаад сэргээсэн “Саломея” хоёр. Вадим энэ хоёроор яс модыг нь зангидаж байгаад Коонены яриа хөөрөөгөөр чимэглэж ярилцлагаа босгохоор шийджээ.

Сарнай цэцгийн баглаа барьсан Вадим хорин зургааны товлосон цагт хаалганы хонхыг дарав.

Коонен өөрөө хаалгаа онгойлгоод,

-Нөгөө тэвчээргүй сэтгүүлч чинь та юу? гээд инээмсэглэв.

-Харин, би, жаахан... хэмээн Вадим түгдчив.

-Зовох юмгүй ээ, ажилдаа бол би ч бас адгуу хүн. Таны нэр Вадим бил үү? Би зөв тогтоож уу?

Вадим цэцгээ гардуулаад пальтогоо тайлав.

Өрөө рүү орж суух хооронд Коонен Вадимыг ажиглаж байснаа,

-Та ээжтэйгээ их адилхан юм байна, би Евгения Федоровнад хайртай байсан юм гэж өгүүлснээ тэс өөр юм руу орж, -Та бод доо, “Бадрангуй эмгэнэл” гэдэг нэрийг чинь би бодож олсон юм. Нэг орой Александр Яковлевичийн өрөөнд орсон чинь Вишневский байж байна. мань хүн жүжгийг нь эмгэнэлт жүжиг гээд байгааг огт зөвшөөрөхгүй өрөөн дотуур нь холхин байна. Александр Яковлевич түүнд, ямар ч атугай, эмгэнэлт жүжиг биччихсэнийг нь ойлгуулах гэж оролдож байна.

-Тийм л болог, гэхдээ миний жүжиг бадрангуй жүжиг шүү! гэж Вишневский зүтгэлээ.

-Тэгвэл яг тэр хэвээр нь “Бадрангуй эмгэнэл” гээд нэрлэчихвэл яасан юм бэ? гэж би хэллээ.

Вадим товч тэмдэглэж авснаа, дэвтрээсээ харцаа салгав.

-За, танд өөр юу ярьж өгөх вэ?

-Та шинэ дүр авахдаа чөлөөтэй тоглоно гэж боддог уу, эсвэл дотроо зохиогчийн хүсэл санаархлыг бас бодолцох уу?

Коонен инээд алдав.

-Миний дотроо боддоггүй ганц зүйл тэр. Эрх чөлөө зайлшгүй хэрэгтэй. Эс тэгвэл Александр Яковлевичийн хэлдгээр, театр биеэ даасан урлаг байхаа больж, зохиогчийн санааг улигласан пьанз болж хувирдаг юм.

Тэгж хэлээд Коонен Вадим руу инээвхийлэн харав.

-Энэ харьцуулга танд ямар санагдаж байна? Надад бол, жишээ нь, тун оносон санагддаг юм. Та манай “Негр”-ийг үзсэн үү?

-Үзэлгүй яахав.

-Тэгвэл би О`Нилтэй холбоотой нэг сайхан жишээ танд хэлье. Ингэхэд, Стефан Цвейг “Негр”-ийг үзэхийн тулд Венаас Москвад явган очсон ч болно” гэж ярьдаг байсан юм гэснээ Коонен өөр юм бодсон уу, Вадимд Цвейгийн үгийг үнэлэх боломж олгосон уу, түр чимээгүй болов. -“Нарбанзадын доорхи дурлал”-ыг үзсэн үү?

-Үзсэн, хоёр ч удаа.

Коонен түүн рүү дахиад чимээгүй харав.

Вадим харцыг нь төдий л ойлгохгүй байлаа.

-Надад их сайхан санагдсан шүү.

-Танд баярлалаа. Гэхдээ би Эббийн дүрийг тэр үед Америкт үзүүлдэг байснаас тэс өөрөөр тоглосноо танд хэлэх гэсэн юм. Тэнд Эббаг сөрөг дүрээр гаргадаг. Би бол түүнийг үнэхээр эмгэнэлт дүр гэдгээр харуулахыг зорьсон юм. Эббаг буруутгах бус, сүйрэлд хүргэсэн уг язгуурыг нь илчилж зөвтгөх ёстой. Эбба ёс суртахууны эрэмдэг балай биш аймшигтай эмгэнэлт хувь тавилантай хүмүүн.

Коонен босч шүүгээний тэнд өлгөсөн жаазтай зургаа авчирч Вадимын урд тавив.

-Энэ бол О`Нил гээд босоо гэрлээ асааснаа, -Та харж байна уу, энд “Эбби Элла хоёрын дүрийг надад амилуулж өгсөн хатагтай Алисе Кооненд” гэж бичсэн байна. Бусад нь магтаалын үгс, түүнийг унших албагүй. О`Нил бидний жүжгийг Парист үзсэн юм. Парисын хаяа дүүрэгт суудаг хүн чинь манай тоглолтыг үзэх гэж зориуд хүрэлцэн ирсэн шүү гэв.

Тэгээд зургийг байранд нь буцааж өлгөөд сандлаа налан тухлан суув.

-О`Нил бас юу гэж хэлсэн гэж санаж байна: Бүтээлч зөгнөлийн театр хэзээд миний чин хүслэн байсан. Камерын театр энэ мөрөөдлийг минь биелүүллээ! гэж айлдсан. Вадим, та яагаад биеэ бариад, гэрбишээд байна аа. Тэр тусгүй шүү.

Вадим бие нь тавирах шиг болж инээмсэглээд,

-Тэгвэл “Федра”-гийн тухай ярилцвал ямар вэ? Жан Кокто “Таировын “Федра” бол хосгүй бүтээл” гэж бичсэн удаатай гэв.

-”Федра”-гийн тухай дэндүү их бичигдсэн, дэндүү их яригдсан... Бараг хүн мэдэхгүй нэг юмны тухай ярьж өгвөл дээр байх. Бид

хорин гурван онд Парист очихдоо “Федра”-г авч очсон юм. Парист очсон анхны орой амьтан хүн олноороо цугласан уулзалт болж, санаа сэтгэл ч сайхан байлаа. Тэгсэн чинь Сара Бернарыг шүтэн хүндлэхийн учир, түүний тоглодог жүжгүүдийн дотор байдаг “Федра”-г францын төдийгүй явуулын нэг ч жүжигчин олон жилийн турш энд тоглоогүй гэхийг гэнэтхэн сонслоо. Дотор палхийгээд явчих нь тэр. Та миний байдлыг төсөөлж байгаа биз дээ? Айх, эмээх, бэргэх бүгд зэрэгцээд. Тэгтэл нэг тохьтой сайхан хүн, сэтгүүлчдийн хүрээнийх болов уу, намайг жаахан хөндийрүүлж, нэг жижиг нөхөрсөг зөвлөлгөө өгөх зөвшөөрөл хүслээ. Тэгээд “Та Парист “Федра”-г тоглохоор ирсэн оросын залуу жүжигчний хувьд манай францын аугаа их жүжигчинд хэдэн үг бичиж түүнээс ерөөл авбал зүгээр мэт надад санагдана” гэдэг байна. Ёстой сайхан зөвлөгөө. Өглөө нь би Сара Бернард хүндэтгэлийн зурвас, цэцэгний хамт илгээсэн. Харин миний захиаг их жүжигчин уншаагүй гэж бодож байна. Юу гэвэл, маргааш нь олон сонины нэгдүгээр нүүрэнд “Манай аугаа их Сара нас нөгчлөө” гэсэн эмгэнэлийн мэдээ гарсан юм.

Германд зочилж тоглосон тухай ярилцацгаав.

-Харин тэнд очиход бид “үл мэдэгдэх большевикууд” байхаа больчихсон байсан. Парисын амжилтын тухай дуулиан тийшээ аль хэдийн хүрчихсэн, манай театрыг хүлээцгээж байсан байна лээ. Германы үзэгчид, театрын хүрээнийхэн бидний тоглолтыг шагшин магтахын зэрэгцээ Таировын найруулгын арга барилыг их сонирхож байсан. Яг тэр үеэр Таировын “Найруулагчийн тэмдэглэл” ном герман хэл дээр гарсныг ч хэлэх үү.

-Александр Яковлевичийн дурсгалын гарын үсэгтэй тэр ном манайд бий, танд зориулсан юм билээ гэж Вадим завсраар нь өгүүлэв. Тэрээр биеэ барихаа нэгэнт больжээ. Одоо “Саломея”-гийн тухай ганц асуулт л үлдэж.

Коонен бодосхийснээ,

-Бид тавин миунт ярилцлаа, би цагийг яг мэдэрдэг юм. Тийм байна уу, та шалга даа?

Вадим цаг харж,

-Яг тийм байна, одоо таваас таван минут өнгөрч байна гэв.

-Дахиад хэдэн минут танд зориулья. Тэмдэглэх хэрэггүй, зүгээр л сонсчих. Та Уайльдын тэр жүжгийг санаж байна уу?

Вадим түүнийг саналгүй яахав. Библийн сэдэвтэй. Ирод хааны дагавар охин Саломея зөнч мэргэн Иоканаанд сэтгэл алдсан эмгэнэлт явдлын тухай жүжиг.

-Хоёрдугаар сарын хувьсгал хүртэл “Саломея”-г сүм хийдийн цензурээр хориглосон байсан юм. Тэр хоригийг халсны дараа Бага театр манайх хоёр тавьсан. Таиров энэ жүжгийг найруулахдаа дүрүүдийн сэтгэлийн яндашгүй их хүч, хүсэл тачаалд нь өөрийн эрхгүй хөтлөгдсөн. Александра Экстер ч тайзны зураг чимэглэлийг гарамгай бүтээсэн.

-Александра Экстер ий? гэж тэмдэглэж авч буй дүр үзүүлэн давтан асуув. Ээ, тэнгэр гэж дээ, тэр хүүхний нэрнээс болоод эцэг нь Таировын номыг цоожтой саванд хадгалдаг байх нь, гэтэл Коонен түүнийг бахархан дурсаж байна!

-Би “Саломея”-г дурсах болгондоо жихүүцэх шиг болдог юм. Яаж салхи савир авчихдаггүй, ханиад томуу тусчихдаггүй байсан юм бэ, ёстой бүү мэд, театрын танхимын дулаалга байхгүй, үзэгчид дулаан пальтотойгоо сууцгааж байхад бид нар бараг нүцгэн шахуу тоглоцгооно. Гэхдээ энэ жүжиг манай театрт ач буянаа өгч, манай нэр хүндийг Москвагийн театрын хүрээнийхний дунд их өргөсөн. Бид энэ жүжгээр Бага театраас давж гарсныг ер нь нийтээрээ хүлээн зөвшөөрсөн дөө.

Вадим явахаар үүдэнд очихдоо,

-Ярилцлагыг та эргэж үзэх хүсэл байх уу? гэж асуув.

Коонен инээмсэглэн,

-Хэрэггүй ээ, би танд итгэж байна гэснээ, -Танд тавдах эгнээний суудал аятайхан санагддаг уу гэж санаандгүй асуув.

Вадим юу гэж хариулах учраа ч олсонгүй.

-Энэ бол хамгийн эвтэйхэн эгнээ. Би танд арван долдугаар суудлыг сул хадгалуулж байя. Манай жүжгийг ирж үзэж байгаарай. Тантай ярилцахад их сонин байлаа.

Ежов Зиновьев, Каменев хоёр дээр бүдэрсэнд Ягода дотроо их баярлажээ. Сталины хувьд улс төрийн санаа бодлыг нь хэрэгжүүлэх ганц хүн нь урьдын адил Ягода хэвээр байна. Ежовыг цаашид хэрхэх төлөвлөгөөгөө бодож байх хооронд ямар ч аргаар хамаагүй түүнээс өрсөх хэрэгтэй. Ягода Ежовоос туршлагатай болохоор Зиновьев, Каменев хоёр эсэргүүцээр байгаа ч тамирдаж сульданд, зовлонгоос халширч бууж өгөх нь юу юугүй ойртсоныг мэдэрчээ.

Ягодын шийдвэрээр Зиновьевын өрөөний халаалгыг бас нэмжээ. Халуун гэж тэсэхийн арга алга. Зиновьев багтраа хуучтай, гэтэл элэг цөсөөр нь хатгуулж эхлэснийг ч хэлэх үү, шалан дээгүүр тийчлэн хөрвөөж, дэмий л эмч дуудахыг шаарджээ. Гэтэл эмч нэг хуурай эмээр ам хаах төдий болж, түүнийг ууснаар улам дордов. Зиновьев, Каменев хоёрыг үхүүлж л болохгүй гэдэг ганцхан үүрэг эмчид өгсөн юмсанж. Үхвэл нөгөө шүүх ажиллагаа тасрах нь тэр.

Тэдний биеийн байдлыг Ягодад цаг тутам илтгэнэ. Тэрээр аль ч хоромд тэднийг бууж өгч мэднэ гэж үзэж байгаа учраас яамнаасаа гарахгүй, албан өрөөндөө хонож байлаа. Тэгтэл ч тэвчээр алдрах нөгөө мөч ирэв бололтой: Зиновьев Молчановтай нэн даруй уулзуулахыг шаарджээ.

Зиновьев Молчанов дээр ороод, Каменевтай ярилцах зөвшөөрөл олгохыг хүсчээ. Зиновьев бууж өгөх төлөвлөгөөгөө бодож буйг Молчанов дор нь ойлгов. Тэрээр Ягода руу угасдаж Зиновьевын шаардлагыг танилцууллаа. Ягода бас бүгдийг ойлгож түүнийг өөр дээр нь авчрахыг тушаав.

Ягода Зиновьевыг ялдамхан угтаж,

-Эрхэм Григорий Евсеевич! Өөрийгөө ч, бид бүхнийг ч энэ хар дарсан зүүднээс салгаж өгөөч ээ. Би таныг Каменевтай нэн даруй уулзуулна. Та хоёр хоюулхнаа уулзана, хичнээн удаанч хамаагүй ярилцацгаа. Харин Григорий Евсеевич, ганц л юм гуйя: Хэрсүү ухаалаг байж үзээрэй! гэж аргадав.

Дараа нь Зиновьевыг нэг хорих өрөөнд оруулж, төдөлгүй Каменевыг ч тийш нь аваачжээ. Тэгээд хоюулхныг нь үлдээв. Тэр өрөөнд нэг ширээ, хоёр сандал байв. Тэнд микрофон зоосныг сайхь хоёр, мэдээж, яаж мэдэхэв.

-Гарц алга хэмээн Зиновьев амьсгаадан өгүүлэв. -Шүүх хуралд орьё. Надад цаашид тэсэх хүч алга.

-Надад ч бас хүч алга, гэхдээ энэ бүхэн эрт орой алин боловч дуусна. Тэсэх хэрэгтэй гэж Каменев хариулав.

-Хэрвээ бид шүүх хуралд оролцвол манайхны гэр бүл, мөн бусад яллагдагсадын гэр бүлийнхний амь насыг аврана. Чи бид хоёргүй шүүх ажиллагаагаа эд нар хийж чадахгүй, юуны өмнө бид хоёр л хэрэгтэй байгаа. Хэрвээ шүүх ажиллагаа бүтэхгүй бол Коба зөвхөн биднийг, зөвхөн манайхны гэр бүлийг хөнөөгөөд зогсохгүй, бусдыг бүгдийг нь, бас гэр бүлийг нь устгана.

Тэрээр амьсгаагаа жаахан дараад үргэлжлүүлэн ярив.

-Бид зөвхөн өөрснийгөө, гэр бүлийнхнийгээ бодох төдийгүй бидний талд байсан мянга мянган нөхөд, тэдний гэр бүлийн тухай бодох үүрэгтэй. Бид тэднийг хариуцаж байгаа. Тийм учраас би нэг болзол тавихыг санал болгож байна: Сталин бидний болон ма-найхны гэр бүлийн амь нас, манай талд явсан хүмүүс, тэдний гэр бүлийнхний амь насыг хөндөхгүй гэж баталгаа өгөх ёстой. Заавал бидний гэхийн учир юу вэ? Амь насыг маань амласнаар биднийг гэмт хэрэг үйлдсэний төлөө яллах тухай асуудал биш, Троцкийг алан хядах ажиллагаа явуулсан гэж мэдүүлсний хариуд бидний амь насыг хэлтрүүлж буй наймааны асуудал яригдаж байна гэдгийг Сталин чухамдаа нотлоно гэсэн үг, ер нь бидэнд хийсэн хэрэг байхгүйг тэр өөрөө сайн мэдэж байгаа.

-Цаадах чинь юу гэж ч амласан чадна, тэгээд л залилчихна. түүнд итгэж болохгүй.

-Бид түүнд өөрт нь бус, бидэнд албан ёсоор өгөх баталгаанд нь итгэх юм.

Зиновьев нугарсан нь тодорхой боллоо. Шүүх ажиллагаанд оролцож тэдний шаардсан мэдүүлгийг, түүний дотор Каменевын өөрийнх нь тухай хүртэл мэдүүлгийг өгөх юм байна.

Сталины амлалт хэсэг зуур биелэгдэнэ, хэр удаан тийм байх нь өөр асуудал. Гэхдээ түүний тулгалтыг хүлээж авсан хүний хувьд л тэр шүү дээ. Татгалзсан хүнийг бол нэн даруй үгүй хийнэ, өөрийг нь, гэр бүлийг нь, үр хүүхдийг нь, бяцхан Юркаг ч үгүй хийнэ.

-Ийм жигшүүртэй юм хийхдээ хүрвэл Сталин Улс төрийн Товчооны бүх гишүүний нүүрэн дээр баталгаа өг гэсэн нөхцөл заавал тавих хэрэгтэй. Бүх гишүүний нүүрэн дээр гэдгийг давган хэлье. Тэгж гэмээ нь баталгаа түүнийх биш, Улс төрийн Товчооных болно. Тийм баталгааг зөрчих болвол Улс төрийн Товчооны шийдвэр заавал гарах шаардлагатай болно гэж Каменев хэлэв.

-Зүйтэй хэмээн Зиновьев зөвшөөрөв.

Тэр хоёрыг Ягода дээр авчирмагц Каменев уг болзлоо түүнд мэдэгджээ.

Ягода Сталинд илтгэхээр амлав.

Уул нь тэр хоёрыг өөр рүү нь авчирч явах хооронд амжуулаад илтгэчихсэн юм байж. Нууц микрофоноор дамжуулан Ягода тэдний яриаг эхнээс нь аваад эцсийг нь хүртэл үг бүрчлэн сонссон бөгөөд Ежов санамсаргүй ирж Каменевын шаардлагыг сонсчихоод өөрөөс нь өрсчихөж магад хэмээн болгоомжилж, Сталинд тийнхүү яаруу утасджээ.

Ягода тун додигор байв. Зиновьев Каменев хоёрыг ялсан гавьяа түүнд, түүний аппаратад ноогдлоо. Сталин ч бас сэтгэл хангалуун байж.

Гэхдээ бүх юм Ягодын бодож байснаас өөрөөр эргэжээ. Сталин Молчанов, Миронов тэр гурвыг нэн даруй ирж, тодорхой илтэг гэж тушаалаа.

Сталин илтгэлийг чимээгүй сонссоны эцэст царай нь барайн, сайхь гурав руу муухай харав.

Нэг их маадгар амьтад сууцгаах шив. Хөл нь газар хүрэхгүй хөөрцгөөчихөж. Юундаа ингэтлээ хөөрч байна? Шүүх ажиллагааны бэлтгэлийг хангасандаа тэр үү? Тэр ч аргагүй, даалгавар биелүүлсэн, ая тал засахын түүс болсон улс чинь. Гэхдээ жинхэнэ шалтгаан нь өөр. Зиновьев, Каменев, Смирнов, Мрачковский дөрвийг авар-сандаа, Ольберг мэтийн муусайн баасыг аварсандаа хөөрцгөөж байна, гарцаагүй. Тэдний амь насыг э д н а р хамгаалан үлдээж, “Лениний журмын нөхөд”, ахмад большевикуудыг хөнөөсөн гэх сэтгэлийн сэвгүй, цэвэрхэн үлдэцгээнэ гэж тооцоолж байх нь. Зиновьев, Каменев хоёрыг мань хүн, Сталин, өөрөө л өршөөнө шүү дээ. Энэ улс төрийн хувьд алдаатай шийдвэрээс үүдэн гарах уршгийн хариуцлагыг нөхөр Сталин өөртөө авна, тэгэхэд энэ муусайн цэргийн хувцастнууд Зиновьев, Каменев энэ тэрийг аварсан хүнлэг, хүмүүнлэг, сэтгэлийн сэвгүй чекистүүд байх юм гэнэ. Улс төр, ёс суртахууны хувьд аль хэзээний сүнс болчихсон тэр муу хоёрыг гүйцээгээд буулгаад авч чаддаггүй заяагүй хоолны савнууд, новшны донтнууд, гар хумхигчид, муусайн садарлагчид. Одоо эдний өмнөөс энэ ажлыг ӨӨРӨӨ гүйцээх ёстой юм уу?

Сталин босч өрөөн дотуураа холхиж эхлэв.

Ханан талд сууж байгаа Ягода, Молчанов, Миронов гурав намбалаг, зугуухан холхиж буй Сталиныг түгшүүрлэн харцгаана.

Тэгж тэгж Сталин сая ам нээв.

-Зэрвэсхэн харахад энэ бол муугүй л юм. Гэхдээ зөвхөн зэрвэсхэн харахад шүү. Тэд амь насаа аврахыг хүсч байна уу? Гарцаагүй. Амь насаа алдая гэх нэг ч хүн байхгүй. хэнд ч амьдрал аргагүй үнэтэй зүйл. Зиновьев, Каменев хоёр ч амь насаа аврахыг хүсч байна. Амь насаа өргөдөг хүмүүс бас бий. Гэхдээ тэд бол чин хүслэнтэй, түүний-хээ төлөө үхэхэд бэлэн байдаг хүмүүс. Зиновьев, Каменев хоёрт тийм чин хүслэн байхгүй. Тэр хоёр чин хүслэнгээ аль хэдийн гээсэн, тийм учраас үхэн хатан эрмэлзэх юм байхгүй. хүн амь насаа зориулдаг өөр шалтгаан бий, энэ бол нэр төр, коммунистын нэр төр, большевикийн нэр төр. Зиновьев, Каменев хоёрт ийм нэр төр бий бил үү? Мэдээж байхгүй. Тэд өчнөөн жил нам, ажилчин ангийг хуурч байна, тэд нэр төр, хүн мөсөө нэгэнт гээсэн, амь насаа зориулах юм энэ тухайд байхгүй. Жирийн хүний хувьд амь настайгаа зууралдаж байна уу? Үгүй ээ, тэд өөрсдийгөө жирийн хүмүүс гэж үзэхгүй буй. Тэд нар өөрсдийнхөө боловсон хүчнийг аварч үлдээх санаатай байгаа юм. Тэдний өдүүлсэн бүх гэмт хэргийн хариуд амь насыг нь соёрхох юм бол тэдний жирийн дагалдагсадтай ямар юмных нь хариуцлага тооцох вэ дээ? Тэдний хорон санаа чухам энэ. Өөрсдийгөө аврах, тэгснээрээ боловсон хүчнээ аврах. Тэдний шаардаж буй баталгаа чухам энэ. Тэгвэл нэг асуулт гарч ирж байна. Нам яахаараа тэдэнд тийм баталгаа өгөх ёстой юм бэ?

Сталин намбалаг зугуухан холхисон чигээрээ чимээгүй болов.

Хэрэг явдал ингэж эргэсэнд балмагдсан Ягода, Миронов, Молчанов гурав бүлх залгисан мэт сууцгаана. Сталин шийдвэрээ өөрчилчихөж. Яллагдагсад амь насны баталгаа өгөхгүй нь. Гэхдээ шүүх ажиллагаа болох ёстой, мань хүн үүнийг заавал шаардана, тэгэхээр Каменев Зиновьев хоёроос өөр аргаар шаардлагатай мэдүүлгээ авах ёстой болох нь.

Сталин ширээ рүүгээ ирж суув.

-Та бүхэн тэдэнд ямар нэг баталгаа өгсөн үү?

-Нөхөр Сталин, хэмээн Ягода ам нээв. -Бид тэдэнд ямар ч баталгаа өгөөгүй, баталгаа өгөх эрх бидэнд байх ч үгүй. Баталгааг тэд л шаардсан, гэхдээ биднээс биш, Улс төрийн Товчооноос шаардсан. Бид шаардлагыг Улс төрийн Товчоонд уламжлана гэдгээл амласан.

-Амласан гэнэ ээ, тэдэнд Улс төрийн Товчоотой наймаалцахыг амлаа юу? Тэгвэл Улс төрийн Товчоо тэгж наймаалцаж болох уу? Энэ тухай та бүхэн бодсон уу? Мөрдлөг ямаршуухан чигтэй явсныг би одоо л ойлголоо.

Сталин азнасхийснээ үргэлжлүүлэв.

-Та нар тэдний шаардлагыг нөхөр Сталинд уламжлахыг амлаж. Тэгвэл нөхөр Сталин юу гэж хариулах ёстой вэ? Тийм уулзалтыг зөвшөөрөхгүй гэх үү? Тэд үүнийг юу гэж үзэхэв? Алах ялтай адилтгаж үзнэ. Тэгвэл шүүх хуралд оролцохын хэрэг юу вэ? Та нарын хийсэн ажил ямар хэрэгтэй болохов? Та нар хагас жил үүнтэй ноцолдсон, ямар ч үр дүнгүй хоцрох нь. Тэдний шаардлагыг Товчоонд уламжлана гэж алдаа хийсэн байна. Та нар тэднийг сонсоод шаардлагыг нь хэлэлцэнэ, өөрсдөө хэлэлцэнэ гэж хэлэх ёстой байсан юм. Тэгээд бидэнтэй зөвлөх ёстой байсан, тэгвэл бид тийм шаардлагыг Товчоонд уламжилж чадахгүй, тийм эрх байхгүй гэж тэдэнд хэлэхийг зөвлөх байсан юм. Өөрсдөө л хувь заяагаа шийдэцгээнэ биз. Та нар ингэх ёстой байсан юм. Та нар ингэсэнгүй.

Тэрээр чимээгүй болзгносноо үргэлжлүүлэв.

-Одоо алдаагаа яаж засах вэ гэсэн асуулт гарч байна. Би бол ганцхан гарц харж байна...

мань хүн нөгөө гурвыг сэлгүүлэн муухай харав.

-Бид энэ шаардлагыг няцаавал, дамжуулна гэж амласан та нар ажилтнуудынхаа өмнө нэр нүүрээ хөөднө. Бид үүнийг хүсэхгүй байна. Бид ДЯАК-ын удирдлагыг хөөдөхийг хүсэхгүй байна. ДЯАК-ын удирдлагыг бид үнэлж, дэмжиж байгаа. Зөвхөн энэ учраас Улс төрийн Товчоо Зиновьев, Каменев хоёрын тулгалтыг хүлээж авахаас өөр аргагүй болж байна. Гэхдээ энэ бол анхны бөгөөд эцсийн тохиолдол. Хойшдоо та нар тийм шаардлагыг з ө в х ө н сонсож болно, уламжлахыг амлах эрх байхгүй. Үүнийг тогтоож авцгаа.

Молчанов, Миронов хоёр Зиновьев, Каменев хоёрыг дундаа хаалттай битүү суудлын машинаар Кремльд авчирав.

Ширээний ард Сталин, Ворошилов, Ежов гурав сууж байна. Ягода хананы тэнд суужээ.

Сталин Зиновьев, Каменев хоёртой мэнд ч мэдэлгүй хананы тэндэх сандал руу гараараа тоомжиргүй дохив.

Зиновьев, Каменев хоёр суулаа. Миронов, Молчанов хоёр тэдэнтэй зэрэгцэхийн суудал эзлэв.

Сталин Зиновьев, Каменев хоёрыг танихгүй хүн шиг нэг хэсэг хайхрамжгүй харав. Хуучин

явдал ор байгаагүй мэт улиран одож, одоо эд нарын тухай дурсчихаар ч юм алга. Нухлагдсан хулчгар хоёр толгой. Энэ муу өчүүхэн хоёр түүнийг унагахыг санаархсан. түүнийг түлхэн унагаах гэсэн! Ялтангууд, шаарнууд! Аль хэдийн устгавал зохих байсан юм.

-За, та хоёрыг сонсоё гээд Сталин царайгаа барайлгав.

-Биднийг Улс төрийн Товчоо сонсоно гэж бидэнд амласан гэж Каменев өчив.

-Улс төрийн Товчооны бүх гишүүд та хоёрыг харах гэж, сонсох гэж хот, хөдөөд ажлаа хаячихаад ирнэ гэж та нар тооцоолоо юу? Тэгвэл тэд та хоёрыг ханатлаа харсан, ханатлаа сонссон.

Каменев Зиновьев руу харав.

Сталин Каменевыг мэдэхийн цаагуур мэдэх учраас тэрхүү харцыг анзаарангуут дор нь ойлгов. Улс төрийн Товчоо бүрэн бүрэлдэ-хүүнээрээ сонсоно гэж тэдэнд амласан, түүн дээрээ хатуу зогсохыг Каменев харцаараа Зиновьевоос уриалжээ. Каменев хэзээнээс нааш Зиновьевын бараанд л явж ирсэн хүн. Харин өнөөдөр бол энэ хосоос Зиновьев нь илүү доройтсон, илүү дуулгавартай байна.

-Улс төрийн Товчооны комисстой ярилцахад та нарт учир дутагдалтай байгаа бол энэ уулзалтыг ингээд дуусгаж болох юм гэж Сталин хэлэв.

Сталины тооцоо яг оножээ. Зиновьев сандлаасаа босов.

Хуучин Зиновьев эмэгтэй хүнийх гэмээр шингэн, бараг цахир дуутай билээ. Одоо бол үгээ эвлүүлж ядан аяархан, удаан ярьж байна. Хөгшин чавганц! Хэзээний чавганц. Царай нь ч чавганцынх. Нэр төртэй үхэж ч чадахгүй шүү. Өөрөө бол хунз хунзаар нь тонилгож байсан шүү дээ. Тухайн үедээ Петроградад хичнээн хүнийг нядаллаа даа. хэнийг ч хайрлахгүй байсан, одоо болохоор өөрийгөө хайрлаж, өөрийгөө өрөвдөж байна. Намын доторхи тэмцэлд ялсан бол нөхөр Сталинтай ийм яриа хэлцээ хийхгүй, буудаад алчих байсан даа. Өнөөдрийн энэ байдлаас бултаж гарна гэж үнэнээсээ бодож байна гэж үү?!

-Кировын алуулсанд Лев Борисович бид хоёрын хэн нь ч, ямар ч холбогдолгүй байсан... Та бүхэн үүнийг маш сайн мэдэж байгаа...

Зиновьев толгойгоо өлийсхийн Сталины нүд рүү эгцлэн харав. Гэвч Сталин хараа буруулсангүй.

-Гэвч...

Зиновьевын толгой гудайв...

-Гэвч энэ аллаганы төлөө ёс суртахууны хариуцлага хүлээхийг... хүлээхийг биднээс шаардсан... Бидэнд таны үгийг уламжилсан... бид ингэж хүлээх нь намд зайлшгүй хэрэгтэй гэсэн таны үгийг...

Зиновьев амьсгаагаа дарав.

-Бид нэр төрөө золиосолж үүнийг хүлээн зөвшөөрсөн... Гэтэл биднийг хуурсан болж таараад шоронд хийчихсэн...

Тэрээр дахин амсхийв.

-Тэгэхээр та одоо юу хүсч байгаа юм бэ? Одоо биднийг дахиад шүүх хуралд оролцуулахыг хүсч байна. Тэр шүүх хурал дээр ленинч Улс төрийн Товчооны гишүүд явсан, Владимир Ильичийн хувийн анд нөхөд биднийг танхай балмад алуурчид болгон дүрслэх гэж байна... Энэ биднийг шившиглээд зогсохгүй намыг маань хүртэл шившиглэнэ шүү дээ... энэ намд чинь бид сайн ч, муу ч бүх насаа зориулсан...

Зиновьев уйлчихав. Молчанов түүнд ус аягалж өглөө. Сталин Зиновьевын нулимсыг тоосон шинж алга.

-Каменев та хоёрын байр суурь, Каменев та хоёрын явдал сайн юманд хүргэхгүй гэж ТХ нэг бус удаа сануулж байсан. Яг тийм л болж таарсан... Намдаа захирагд, тэгвэл амь настайгаа үлдэнэ гэж бид та нарт дахиад л хэлж байна. Дургүй байна уу? Дахиад л хүсэхгүй байна уу? Тэгвэл яая гэхэв, хар толгойдоо л гомдоорой.

-Биднийг удаа дараа хуурсан, одоо хуурахгүй гэдгийн баталгаа хаана байна? гэж Каменев асуув.

-Та нар баталгаа шаардаж байна уу? гээд Сталин ихэд гайхсан дүр эсгэн Ворошилов руу харав. -Эд нар баталгаа шаардаж байна! Улс төрийн Товчооны баталгаа тэдэнд чамлалттай байх нь! Манай оронд үүнээс дээш баталгаа байхгүйг эд нар мартчихаж! гэснээ Сталин дахин Ворошилов руу, дараа нь Ежов руу харж, -Та нөхдөд ямар санал байна? Миний бодоход энэ бол цаг дэмий үрэхээс цаашгүй яриа байна хэмээв.

Бүх юм тодорхой байна гэх маягтай Ежов дал мөрөө хавчив.

-Эд нар өөрсдийнхөө болзлыг бидэнд тулгахыг санаархаж байна. Нөхөр Сталин амь насыг нь аврах гээд байгааг эднүүс ойлгохгүй байна, эсвэл ойлгохгүй дүр үзүүлж байна. Амь насандаа хайргүй юм бол хохь нь! Чөтгөр шулам руугаа тонилцгоог! гэж Ворошилов бухимдав.

Нэг хэсэг хэн ч дуугарсангүй. Сталин,

-Зиновьев, Каменев хоёр бэртэгчин шиг сэтгэж байгаа нь тун харамсалтай байна. Тун харамсалтай. Шүүн таслах ажиллагааг юуны тулд зохион байгуулж байгааг хүртэл эд нар ойлгохгүй байна. Эднийг буудан алах гэж тэгэх үү? Нөхөд минь, ийм тэнэг юм гэж байх уу, бид ямар ч шүүх хурал хийлгүй эднийг буудан алж чадна шүү дээ. Үүнийг яаж хийдгийг Зиновьев маш сайн мэднэ. Шүүн таслах ажиллагаа Троцкийн эсрэг л чиглэж байгаа шүү дээ. Троцкий намын заналт дайсан гэдгийг Зиновьев, Каменев хоёр нэг үе ойлгож байсан, дараа нь өөрсдөө нам руу дайрч Троцкийн нэрийг цагаатгасан, жигүүр, бүлгийн эрх ашгийн үүднээс цагаатгасан, гэтэл Троцкий намын заналт дайсан чигээрээ л үлдсэн шүү дээ.

Зиновьев, Каменев хоёр үүнийг мэдэхийн цаагуур мэднэ. Тэгэхээр ийм асуулт гарч байна: Зиновьев, Каменев хоёрыг Троцкийтэй хамсан нам руу дайрч байхад нь буудан алаагүй хэрнээ одоо Троцкийн эсрэг тэмцэхэд намд тусласных нь төлөө бид тэднийг яахаараа буудан алах ёстой билээ? Бас, эцэст нь, нэг зүйл байна гэснээ үгээ түр таслан бодолхийлэхэд нүдэнд нь хүнлэг, дотносог гэмээр нэгэн гэгээ зурсхийв. Тэгээд гүйцээж хэлсэн зүйл нь санаанд оромгүй сэтгэл хөдлөм, чин зүрхний үг шиг сонсогдлоо:

-Ямар ч хүнд алдаа гаргасан бай, бид цуг зүтгэж ирсэн намынхаа ахмад нөхдийн цусыг урсгах хүсэлгүй байна.

Зиновьев дахин мэгшив. Молчанов ч ус аягалж өгөх гэж дахин босов. Харин түүний царай орж ирж байснаасаа шал өөр болсныг Сталин анзаарчээ. Зиновьев, Каменев хоёрын амь аврагдах нь гэж баярлаж байгаа нь тэр. Бас Миронов ч баярлачихаж. Ягодын орлогчоор ӨӨРИЙНХ нь дэвшүүлсэн Миронов гэдэг энэ хүмүүнлэг амьтан бүр онцгой баярлаж байна.

Арга ч үгүй дээ, эднүүс баярлахгүй яахсан билээ? “Гэмгүй хүмүүсийг” алсны төлөө түүхийн өмнө хариуцлага хүлээхгүй болж байгаа юм чинь.

Яагаад “гэмгүй хүмүүс” байх билээ? Яагаад гэвэл, тэдний бичиг цаасаар, тэдний хууль цаазны дүрмээр зарим зүйл авцалдахгүй байна уу? Тэгвэл ямар цаас, ямар хууль цаазны дүрэм пролетарийн диктатурт хууль болж чадах юм бэ? Пролетарийн диктатурт цорын ганц хууль бий, тэр нь уг диктатурын ашиг сонирхол. Тийм учраас жинхэнэ чекистэд өөр хууль байх ёсгүй. Өөр хууль байгаа бол тэр хүн жинхэнэ чекист биш.

Каменев бослоо.

-Нөхөр Сталин, Улс төрийн Товчооны гишүүн нөхөд өө. Бидэнд тавьсан болзлыг зөвшөөрч, шүүх хуралд оролцоход бэлэн гэдгээ өөрийн болон нөхөр Зиновьевын нэрийн өмнөөс мэдэгдье. Харин сөрөг хүчинд оролцож явсан хэнийг ч болов одоо буудан алахгүй, сөрөг үйл ажиллагаа явуулж байсны төлөө хойшид хэнийг ч буудан алахгүй гэсэн амлалт бидэнд өгөхийг хүсч байна.

Сталин хормын төдийд уярсан сэтгэлээ барих мэт,

-Тэр мэдээж шүү дээ гэж ядарсан шинжтэй өгүүлэв.

Зиновьев, Каменев хоёрыг нөгөө битүү хар машинаар Кремлиэс шоронд нь буцааж авчрав. Гэхдээ шинэхэн цагаан хэрэглэл дэвссэн төмөр ортой шал өөр өрөөнд оруулжээ. Тэгээд тэр даруй шүршүүр энэ тэрд оруулж, хоол унд эрс сайжран, эмчийн зүгээс Зиновьевт шаардлагатай цагаан хоолыг товлож өгчээ. Шүүх хурал хүртлэх хоёр долоо хоногт тэдэнтэй тохиосон хүмүүс боломжийн харьцаж байв.

Тэглээ ч гэсэн 1936 оны наймдугаар сарын 19-ний өдрийн 12 цаг 10 минутад тэднийг Холбооны ордны Октябрийн танхимд шүүх хуралд авчрахад, Зиновьев доод хоёр зовхи нь шалхайж, царай нь сэлхрэн зэгэлтэж сааралтаад тун доожоогүй байв.

Каменевын зовхи шалхайж, бас зэгэл саарал царайтай ч Зиновьевоос арай тэнхлүүн харагдана. Тэрээр олон жил Москвагийн Зөвлөлийн дарга байсан болохоор намын ажилтан баргийн хүнийг зүслэх учир таньдаг хүн олох санаатай танхимд цугларагсадыг хичнээн харсан боловч нэг ч хүнийг зүслэж чадсангүй. Тэнд энгийн хувцас өмссөн ДЯАК-ын ажилтнууд цугласан юмсанж.

Ягода болон яамны бусад удирдлага хажуугийн өрөөнөөс шүүн таслах ажиллагааг сонсоцгоов.

Ганц Рейнгольд л шоронгоос биш гэрээсээ ирсэн мэт эрүүл саруул харагдана. Тэрээр итгэл үнэмшилтэй мэдүүлэхийн зэрэгцээ Вышинский аль нэг зүйлийг эндүүрвэл, үг хэлэх зөвшөөрөл аван түүнийг эвлэгхэн залруулж байв.

Харин Рейнгольдын ингэж хичээх нь илүүц байж. Яллагдагсад цөм шүүх хурлын зохиомжийг ягштал цээжилсэн учир прокурорын асуултад яг шаардлагатай хариултыг нь өгч байлаа. Түүгээр зогсохгүй шүүх хуралдааны явцад тэд нар Сокольников, Смилга, Рыков, Бухарин, Томский, Радек, Угланов, Пятаков, Серебряков, Мдивиниани, Окужава, корпус командлагч Путна, Примаков, дивиз командлагч Дмитрий Шмидт нарыг хуйвалдаанд оролцогчид гэж шинээр нэрлэжээ. Эцсийн өчиг өгөхдөө цөм буруугаа хүлээж, өөрийгөө алуурчин, алан хядагч, зандалчин хэмээн хүлээн зөвшөөрчээ.

Харин Иван Никитич Смирнов л ганцаараа зохиомжийг зөрчжээ. Тэрээр Молчановт амласан ёсоор 1932 онд Троцкийгээс алан хядлагын тухай заавар авсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн боловч 1933 оны нэгдүгээр сарын 1-нд баривчлагдаж, түүнээс хойш шоронд сууж байгаа учир ямар ч алан хядах үйл ажиллагаа явуулаагүй гэж мэдүүлжээ. Түүнчлэн шүүх хуралдааны явцад “төв” байсан гэдгийг үгүйсгэж, Мрачковский, Зиновьев, Евдокимов, Дрейцер, Тер-Ваганян, Каменев нарын мэдүүлгийг няцаажээ.

Смирнов зарим асуултад ерөөсөө хариулсангүй.

Вышинский бүх яллуулагчид буудан алах ял оноох шаардлага тавив.

Наймдугаар сарын 23-наас 24-нд шилжих шөнийн хоёр цаг гучин минутад шүүх ял сонсгов. Бүх яллагдагсадад буудан алах ял заажээ.

Яллуулсан хүмүүс хуулийн дагуу 72 цагийн дотор уучлал үзүүлэх өргөдөл гаргах эрхтэй.

Гэтэл наймдугаар сарын 24-нийхөө өглөө нь бүх яллуулагсадыг цаазын газар аваачжээ.

Зиновьев тэсвэр алдран, Сталины нэрийг барьж, амлалтаа биелүүлэхийг шаардан шоронгоор нэг орь дуу тавьжээ. Тэр орь дууг зогсоохын тулд Зиновьевыг харгалзаж явсан дэслэгч түүнийг шоронгийн хоосон өрөө рүү хөөж оруулаад тэнд нь гар буугаар буудан хороожээ.

Каменев нэгэнт мэгдэн гайхширч, ганц үг хэлэлгүй үхэлтэй чимээгүй золгожээ.

Харин ганц Иван Никитич Смирнов л шоронгийн хонгилоор зоримог тайван алхалж очоод

буудуулахын өмнө “Шүүх хурал дээр арчаагүй зан гаргасныхаа төлөө бид ингэж яллуулах ёстой” хэмээжээ.

Смирновын охин Ольга, гэргий Роза хоёрыг тэр даруй баривчлан 1937 онд буудан алжээ.

Мөн 1937 онд Зиновьевын хүү Степан Радомыльский, Бакаевын гэргий, намын 1917 оны гишүүн Анна Петровна Костина, Мрачков-скийн дүү, ач хоёр, Тер-Ваганяны дүү Энзак нарыг буудан алжээ. Тер-Ваганяны гэргий Клавдия Васильевна Генералова 1936 онд баривчлагдаж хориход 17 жил болжээ.

Каменевыг алснаас хойш удалгүй түүний анхны болон хоёрдахь эхнэрийг буудан алжээ.

1939 онд том хүү Александрьг буудан алжээ.

Каменевын бага хүү Юрийг 17 хүрэхэд нэг сар дутуу байхад нь 1938 оны нэгдүгээр сарын 30-нд буудан алжээ.

Каменевын ач Виталий бүр 1951 онд 19 настай байхдаа баривчлаг-даж, 25 жилээр заагдаад 1966 онд нас баржээ.

Нөхөр Сталин амлалтаа ингэж биелүүлсэн болой.

Вадим “Баатрууд” гэдэг инээдмийн дуурийн анхны тоглолтод Ершиловыг дагуулж очно гэж нэгэнтээ амласан боловч тэр нь бүтсэнгүй. мань хүн нянгийн халдвараар ангинатаад гучин ес хүртэл халууран юун театртэй мантай болжээ. Хоолойгоо риванолоор зайлж элдэвлэсэн боловч юу ч нэмэр байдаггүй, ашгүй Феня хатаасан цагаан мөөг хандалж өгсөн нь бага зэрэг тус болж жаахан шөл балгахтайгаа болжээ...

Хэд хоног юу ч уншаагүй, үйлчлэгчээ сонинд явуулав. Литовский “Советское искусство”-д мундаг шүүмж бичиж “Баатрууд”-ыг шагшин магтжээ. Загорский “Вечерняя Москва”-д бичиж. Вадим Загорскийг уншсангүй, сонингуудаа шалан дээр хаяв. Унших битгий хэл дуурийг нь үзэж амжих юм чинь.

Арван нэгдүгээр сарын 14-нд Ершилов утасдав.

-Сайн эдгэрээгүй байна уу?.. Гэхдээ сонин уншиж дөнгөнө биз дээ? “Правда” унш.

-Тэнд юу гээч гараав? гэж Вадим залхуутай асуув.

-”Баатрууд”-ыг хориглох тухай Урлагийн хорооны тогтоол.

-Арай ч дээ?!

-Арай ч дээ чинь л тэр...

Арваннэгдүгээр сарын 15-ны “Правда” сонинд Керженцевийн “Ардын өнгөрсөн үеийг гуйвуулсан нь” нэртэй өгүүлэл нийтлэгдсэн байв. Керженцев уг дуурийн цомгийг бичсэн Демьян Бедныйг үнсэн товрог болгожээ. Тэрээр өгүүллийнхээ эцэст,

“... Д.Бедныйн жүжиг түүхэн хэсэгтээ түүхийг гуйвуулж, түүхэнд марксист бусаар төдийгүй хөнгөн хуудам хандахын үлгэр, ардын өнгөрсөн үеийг нулиман доромжилсон хэрэг болжээ... Д.Бедный баатруудын тухай зөвхөн “баатарлаг хурхиралтаар” нь дурсаж... оросын ард түмнийг дулаан ханзан дээр хурхирч буйгаар дүрсэлжээ” гэж бичжээ.

Вадим энэ удаа өөрөө Ершилов руу утасдав.

-Сонин юу байна? Би хэвтэрт юу ч мэдэхгүй хэвтэж байна.

-Демьян Бедныйг Кремлийнх нь байрнаас хөөсөн гэлцэж байна хэмээн Ершилов хөхрөв. - Одоо таньдаг айлаараа хонож байгаа юм байх аа... Удахгүй чиний Камерын театр шүүмжлэлийн бай болно, чи харна аа гайгүй. Чи ч гэсэн оролцож таарна.

-Би юундаа оролцох билээ? Одоо би өвчтэй байна, бас “Баатрууд”-ыг ч үзээгүй, чи мэдэж байгаа шүү дээ.

-Үзсэн, үзээгүй нь яахав, гэхдээ оролцож л таарна.

Ямар нэг юм мэдэж байсан хэрнээ яриагүй юм уу, муу Ершилов золигийн хэлсэн үнэн болж таарав. Арваннэгдүгээр сарын 20-ны “Правда” сонинд Үзэгч гэсэн зохиогчтой “Алдааны чиг шугам” нэртэй өгүүлэл нийтлэгдлээ. Театрыг ёстой аймхай мөгөөрс рүү дэлсэх мэт муухай муулжээ... Вадим түүнийг дахин дахин уншиж.

“...Камерын театр нэг бус удаа улс төрийн алдаатай жүжиг тавьсан:

1927 онд Мих. Левидовын “Тэнцүү хүчтэний хуйвалдаан”.

1928 онд Мих. Булгаковын “Нөжирсөн арал”.

1929 онд С. Семеновын “Наталья Гарпова”.

Камерын театрын ийм жүжгүүдийг олон нийт бүхлээрээ, түүний дотор бусад театр хилэгнэн буруушааж, тэдгээрийг тоглохыг хориглосон билээ...

Гэтэл театрын удирдагч А. Я. Таиров алдаатай чиг шугамаа муйхарлан үргэлжлүүлж ирлээ. Тэрээр 1931 онд М. Кулишийн үндэсний дээрэнгүй үзэл нэвчсэн “Хийморлиг эгшиглэн” жүжгийг тавьсан.

Дараа нь Д.Бедныйн улс төрийнхөө хандлагаар эхнээсээ эцсээ хүртэл хуурамч “Баатрууд” гарч ирлээ...

Таиров хамт олны аливаа бүтээлч санаачилгыг нухчин дардаг “хаант засагархуу” дэг театртаа тогтоожээ. Гэтэл тэр театрыг хэн ч түүний “эдлэн” болгоогүй билээ.

Камерын театр сайн жүжигчидээ урагш алхуулдаггүй учраас бүтээлч хамт олныг бүрдүүлж чадсангүй. Энэ театр зөвлөлтийн урлагийн нийт өсөлтөөс хоцорч сүүл мушгиж явна...”

Яг тэр өдөр Вадимын шүүмж, өгүүллээ байнга нийтлүүлдэг нэг сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга түүн рүү утасдав.

-Вадим Андреевич, Камерын театрын хэрэг явдалтай холбогдуулан бид үгээ хэлэх ёстой гэсэн санал байгаа. Бид танаар бичүүлэхийг хүсч байна.

-Үгүй ээ, би бие муу байна, та бүхэн ойлгоорой, ангины дараа хэрэхний хурц хууч хөдлөөд орноосоо босч чадахгүй байна. Чухам энэ өвчин хуучнаас болоод “Баатрууд”-ыг үзэж чадаагүй, бусад нэр дурдагдсан жүжгийг үзээгүй юм уу, үзсэн ч бага байсан болохоор санах юм алга гэж Вадим цааргалав.

-За яахав, редактортоо илтгэе. Вадим Андреевич, таныг татгалзана гэж даанч санасангүй гэж хариуцлагатай нарийн бичгийн дарга туньсан янзтай дуугарав.

Арван нэгдүгээр сарын 23-ны “Правда” сонины зургадугаар нүүрэнд “Камерын театрын хамт олон амаа нээлээ” хэмээх “А. Я. Таиров алдаагаа бүрхэгдүүлж байна” гэсэн давхар гарчигтай товч тэмдэглэл нийтлэгджээ.

Театрын ажилтны хурал хоёр өдөр үргэлжилж, нэр цуутай олон жүжигчин тэргүүтэй хэдэн арван хүн үг хэлжээ.

Урлагийн гавьяат зүтгэлтэн Л. Фенин: “Жүжигчид аль нэг жүжгийг муу болсон гэж үзэж байсан ч, тэднээр албадан магтуулж байсан”.

Вадим Цениний “Таиров жүжгээ хэрхэн найруулах тухай театрын ажилтнуудтай шүүн хэлэлцэх дургүй” гэж хэлснийг үзээд ихэд гайхжээ.

Ценин “Бадрангуй эмгэнэл”-д толгойлогчийн дүрд тоглосон, түүнийг Коонен нөгөө ярилцлага өгөхдөө магтаж байсныг Вадим саналгүй яахав. Гэтэл нөгөө Ценин чинь энэ!

Ер нь Вадим жил хагасын өмнө Коонентой ярилцлага хийж нийтлүүлсэн билээ. Тийм үүрэг авсны учир ярилцлага хийсэн гэж хэлж, мэдээж, болно, гэхдээ мань хүн өөрөө аваачиж өгснийг сониныхон гарцаагүй санаж байгаа. Хэдийгээр гол ярьсан зүйл Кооненых ч гэсэн асуулт, зарим тодотгол гэх мэт нь мань хүн театрыг, тэр алдарт жүжигчнийг бахархан шүтэж байсныг тодхон илчлэнэ. Ингэхэд, чухамхүү энэ тухай өөрт нь одоо сануулахыг ч байг гэхийн газаргүй. түүний амжилтад тэр үед олон хүн атаархаж байсан, одоо хариугаа авцгаана.

Ямар нэг мэдрэмж дутаж, өгүүлэл бичихээс татгалзсан нь мань хүний буруу бололтой. Хариуцлагатай нарийн бичгийн дарга “Редактордоо илтгэе” гэж яггүй тунирхаж байсан. Бас “Вадим Андреевич, таныг татгалзана гэж даанч санасангүй” гэж битүү егсөн.

Гэтэл Ершилов бас гал дээр тос нэмчих нь тэр. Урлагийн хорооны өргөтгөсөн хурлын тухай ярьж өгөх гэж хүрээд иржээ. Тэр хуралд Эльсбейн тэр хоёрыг урьсан юм байж.

-Бие чинь зүгээр байсан бол чамайг ч бас урих байсан. Хурлын тухай дэлгэрэнгүй зүйлийг маргааш юм уу, нөгөөдөр “Советское искусство”-гоос өөрөө уншина биз, харин зарим нэг зүйлийг урьдчилаад мэдчихэд чамд илүүдэхгүй: Керженцев Таировыг улс төрийн талаар дайсагнасан гэж буруутгасан.

-Тэгвэл “Бадрангуй эмгэнэл” юу болж байна? гэж Вадим асуугаад, -Энэ жүжгийн тухай эрхбиш мартамгүйсэн. Тэнд “улс төрийн талаар дайсагнасан” юм даанч байхгүй дээ гэв.

-Тэр тухай бүр дурсаа ч үгүй. Керженцев улайм цайм “Камерын таедр гэдэг нэр бол бузартсан үг” гэж хэлсэн.

мань Вадим ингээд хэрэгт холбогдчих нь энэ... Өгүүлэл бичихээс татгалзсан ёстой тэнэг толгой. Энэ тухай Ершиловт ярих уу, байх уу?

-Саяхан над руу нэг сониноос утасдаж өгүүлэл бичихийг хүсэхээр нь өвчтэй, чадахгүй гээд хэлчихсэн.

-За, боль доо чи... Одоохон утасдаад эдгэчихсэн гэж хэл. Ерөөсөө шууд одоо утасд. Би хүлээзнэж байя.

Вадим утасдчихаад, эргэж өрөөндөө ирж, бүх юм жин тан болсныг мэдэгдэв.

-Тэр чинь зөв, өдөр ойчсон махыг авдаггүй гэдэг шүү.

Вадим, бас нэг дэр нэмж өгөөч гэж Феняд хашгирав.

Хоёр дэр ивээд суувал арай эвтэй байлгүй яахав. Нэг ном авч цаасан дороо хийсэн боловч гулгаад тогтох юм биш. Номын тавиур, ширээ энэ тэрээ эргүүлдэн харвал нэг зузаан дэвтэр хэвтэж байж. Энэ яг болно. Дэвтрээ нээтэл гуравдугаар сарын 22-ны “Chicago Tribune”-ээс авсан тэмдэглэл таарлаа.

“Тэднийг дахин ирнэ гэж бид найдаж байна. Тэд явснаар Парисын тайз гутрана. Европын тайз руу Дорно зүгээс гэгээ туяарч буйг энэ өдрөөс эхлэн бид мэдэж авсан болохоор тэднийг үлгэр жишээ болгон дурсаж бид сэтгэл оюунаараа Орос руу олонтаа хандаж, энэ суут жүжигчдийн буцаж ирэхийг бид тэсэн ядан хүлээх болно”.

Энэ чинь юу билээ? Үүнийг “Москвагийн Улсын Камерын театрын айлчлан тоглосон талаархи өрнөдийн хэвлэлийн улс төрийн үнэлэлт” товхимолоос тэмдэглэж авснаа саналаа.

“Суут жүжигчид!”, “Европын тайз руу Дорно зүгээс гэгээ туяарч байна”... Хөрөнгөтний хэвлэл тэднийг санамсаргүй ингэж шагшин магтаагүй дээ... Эдний урлаг хөрөнгөтөнд таарч байх нь.

Тэрээр Коонены тухай бодмогц сэжиг хүрэх шиг болов. Энгийн хээгүй мэт байсан нь авьяас билгийн өгөөмөр сэтгэлийнх нь биш, тоомжиргүй зангийнх нь байж. Өөрийнхөө тухай, амжилтынхаа тухай л ярих шалтаг олдож байвал хэнтэй ярилцах нь падгүй хэрэг байж. Стефан Цвейг. О’Нил. Жан Кокто энэ тэр гээд...

Үзэгч өгүүлэлдээ Камерын театрт даруу зан дугааж байна гэж зөв бичжээ. Нээрэн, ичих нүүргүй мэт өөрийгөө сурталчлан дэвэргэнэ шүү! “Уралдаанд Бага театрыг ялсан”... Бага театр байсан, байх ч болно, харин та нар тэсч үлдэх үү, үгүй юү, бүү мэд шүү дээ... Бага театр ард түмэнд хэрэгтэй, улс оронд хэрэгтэй, эрхэм хатагтай Коонен гуай, харин та улс оронд хэрэгтэй эсэх нь одоо хэр тодорхойгүй байна. Өрнөдөд та хэрэгтэй, тэр үнэн, Өрнө танд алга ташин баяр хүргэдэг... Харин та манай зөвлөлтийн үзэгчдийн алга ташихийг үзэхгүй.

Андрей Андреевичийг эмнэлэгтээ байхад нь хүүгийнх нь өгүүллийг үзүүлж, магтсан, дооглосны алин болохыг бүү мэд, “Танай хүү мөн лут бичнэ шүү” гэгцгээжээ.

Андрей Андреевич орой нь заншсан ёсоор хүүгийнхээ өрөөнд орж, ор руу нь сандал дөхүүлж суугаад,

-Чиний тэмдэглэлийг уншлаа. Одоо тэр театраас бидний зүг зөв нүдээр харахгүйг чи ойлгож байгаа гэв.

Шал руу харж чимээгүй суузанад босохдоо,

-Чи халуунаа үзсэн үү? гэж асуув.

-Халуун буучихсан. Тэндээс зөв нүдээр харахгүй бол тэр л биз, түүнээс дээр газар олдоно

гэж Вадим бувгнав.

Тэгээд үүргээ биелүүлсэн хүний ёсоор сайхан бөх нойронд автжээ.

Тэгтэл өнгөрсөн удаагийнх шиг өглөөгүүр утас хангинав. Вадим нойрмоглох утсаа автал нөгөө албаны шижээргүй танил дуу сонсоглоо.

-Иргэн Марасевич үү? Та өнөөдөр арван хоёр цагт ЗСБНХУ-ын ДЯАК-д, нөхөр Альтман дээр ирэх хэрэгтэй, пропускийн товчоо Кузнецкийн мост, 24 тоот байшинд бий, тэндээс үнэмлэх аваарай.

Цонх нь торлоостой нөгөө л өрөө. Өлгүүрт өлгөсөн мэт үлхэгэр дүрэмт хувцастай нөгөө л Альтман. Нөгөө л гунигт харц, хонхор хацар.

Альтман ширээнийхээ нүдийг онгичин байж хавтаст хэргийг олоод, дотроос нь түрүүчийн байцаалтын протоколыг гаргаж ирэв. Дахин уншиж байна.

Вадим цаадах нь энэ удаа яаж дүвчигнэхийг мэдэхгүйн харгай-гаар дахин адгуусны айдаст автаж, түүнийг гөлөгнөн ажиглаж суув.

Альтман сүүлчийн хуудсыг уншиж гүйцээд, Вадим руу харах ч үгүй,

-Та мэдүүлэгнээсээ татгалзахгүй биз дээ? гэж үлбэгэр аяархан асуулаа.

-Өө, хаанаас даа, би гарын үсэг зурчихсан шүү дээ.

-Ямар нэг юм нэмж хэлмээр байна уу?

Өөрт нь боломж олгож байна, үүнийг ашиглах ёстой.

-Тэгэхээр юу л даа гэсхийн Вадим эхлэв. -Та өнгөрсөн удаа зөвлөлтийн эсрэг ярианы тухай асууж байсан. Таны асуулт намайг маш гүн бодолд оруулсан. Тийм асуулт тавих ямар нэг үндэс танд байсан, санамсаргүй тийм асуулт тавиагүй гэдгийг би ойлголгүй яахав. Тэгээд би нэг танилдаа санамсаргүй ярьчихсан нэг онигоо тийм үндэс болсон юм болов уу гэж бодлоо.

-Ямар онигоо вэ? гээд Альтман гэдэсхийн сандлаа налж, үнэхээр сонсох гэж байгаа бололтой Вадим руу анх удаа эгцлэн харав.

Вадим нөгөө онигоог төдийгүй хэнээс сонссон, хэнд ярьснаа тодорхой илтгэв. Тэгээд тэр онигоог намын хорооны гишүүний дэргэд сонссон, цаадах нь сонсоод огт тоогоогүй төдийгүй инээж байсан учраас өөрөө ч нэг их ач холбогдол өгөөгүй, тийм учраас хар багаасаа мэдэх үсчин Сергей Алексеевичид ярьсан. Үс засуулаад сууж байхад юу эсийг ярихав, Сергей Алексеевич угаасаа улс төрөөс хөндий, түүний бүх улс төр “Лев Давыдовичгүй бол болдоггүй ээ” хэмээх хэдхэн тоглоомын үгэнд багтдаг хүн хэмээн нэмж тайлбарлав.

Вадим энэ өрөөнд орж ирсэн хойноо чухамхүү энэ гэм халгүй тогтуухан хувилбарыг сонгож авчээ. Өөрт нь бол тун үнэмшилтэй мэт санагдаж л дээ.

Альтман нэг хэсэг чимээгүй болчихов. Ийнхүү чимээгүй буй нь чухамхүү мууг ёрлох мэт, Вадимд итгэхгүй байгаа, дургүй нь хүрч байгааг илтгээд байх шиг.

Тэрээр төдөлгүй нэг цаас авч,

-Дахиад хэл дээ, хэн тэр онигоог ярьсан гэнэ ээ? гэв.

Вадим давтан хэлэв.

-Хэзээ болсон хэрэг вэ?

Вадим өдрийг эс санах тул зөвхөн сарыг нэрлэв.

-Та хэнд ярьсан гэлээ?

Чингэтэл Вадим Сергей Алексеевичийн овгийг мэдэхгүй болж таарав. Альтман энэхүү хослоо нэр, үсчний газрын хаягийг тэмдэглэж авлаа.

-Та өөр ямар ямар онигоог хэн хэнд ярьж байсан бэ?

Вадим дал мөрөө хавчив.

-Би юу? Онигоо юу? Би хэнд ч яриагүй.

-Амьдралдаа үүнээс өөр нэг ч онигоо мэддэггүй байсан гэж

надад нотлох гээ юү? Та надад ийм юм нотлох гэж байна уу?

-Үгүй ээ, хаанаас даа, би амьдралдаа янз янзын онигоо сонсолгүй яахав, гэхдээ хэнд ч дамжуулж ярьж яваагүй.

-Юу сонсож явав даа?

-Санахгүй байна. Ямар ч атугай улс төрийнх л биш.

-Тэгвэл ямар нь вэ?

-Зүгээр ахуйн шинжтэй л...

-Марасевич! Намайг мулгуу амьтан гэж надад нотлох гээ юү? Би мулгуу биш, тийм учраас та намайг мулгууд бүү тооц...

Тэрээр алуурчны сүүмгэр харцаар ширвэн,

-Ер нь энд тэнэг хүн байхгүй! гэж чарлах мэт өгүүлэв.

Вадимд мань хүн гэнэт голын хийтэй мэт санагдаж дотор нь жигтэйхэн арзасхийгээд явчихав. Галзуу хүн чинь яаж ч мэднэ шүү дээ.

-Даан ч санаанд юм орохгүй байна гэж Вадим гүвтнэв.

Альтман түүн рүү муухай харж,

-Санаанд орохгүй байна гэнэ ээ, таны өмнөөс хэн санах болж байна? Би юү? Тэгвэл та миний суудалд суучих, би таныхад сууя гээд босч хажуу тийш болоод суудлаа зааж, -За, суу суу, тийшээ очоод суу! гэж дүвчигнэв.

Энэ галзуу одоо өөрийг нь алчихна, бүсэндээ байгаа гар бууг ганцхан сугалаад буудчихна гэхээс Вадим үхтлээ айв.

Альтман гэнэт боссон шигээ санаандгүй буцаад суучихав. Дахиад чимээгүй болж, өрөөний булан руу бодлогошрон гунигтай харж байснаа гэнэтхэн,

-Зохиолчдын эвлэлийнхэн онигоо ярих уу? гэж асуув.

-Ярьдаг байлгүй.

-Яг хариул. Ярьдаг уу, үгүй юү? “Байлгүй” биш, яг хэл.

-Зохиолчдын эвлэлд хэдэн зуун хүн бий.

-Зохиолчдын эвлэл хэдэн хүнтэйг би асуугаагүй, онигоо ярьдаг уу, үгүй юү л гэж асууж байна.

-Зарим нэг нь ч гарцаагүй л ярьж байгаа.

-Зарим нэг нь гэдэг чинь хэн бэ?

-Би тодорхой хүн нэрлэж чадашгүй нь...

-“Чадашгүй нь?!” хэмээн Альтман шазвалзав. -“Хүсэшгүй нь” гээд л шууд хэлчих... Нэг онигоогоор та баригдсан, түүнийгээ санаж байгаа, өөр нэгээр бас баригдана, тэгээд бусад онигоогоо ч санах болно, даанч тэр үед чинь нэгэнт оройтсон байх вий. За яахав! Александр Павлович Панкратовыг мэдэх үү?

-Панкратов ий? Өө, тийм, Саша Панкратов, мэдэлгүй яахав, бид нэг сургуулийнх.

-Тэр одоо хаана байдгийг та мэдэх үү?

-Тэр чинь баригдаж цөлөгдсөн. Сибирь рүү бил үү дээ.

-Та үүнийг хэнээс олж мэдсэн юм бэ?

-Юу гэсэн үг вэ, бид нэг гудамжинд суудаг, нэг сургуульд сурч байсан, үүнийг бүгд л мэднэ шүү дээ хэмээн Вадим самгардаж эхлэв.

-Үгүй ээ, та ч намайг үнэхээр тэнэг толгой гэж үзэж байгаа юм байна. Танай гудамныхан Панкратовын баривчлагдсанаас өөр юу ч ярихгүй, зөвхөн энэ тухай шуугиад байна гэж та надад нотлох гээ юү? Тийм үү?

-Би ангийнхантайгаа Арбатад тааралдсан юм, тэгэхэд тэд Саша Панкратов баривчлагдсан гэцгээж байсан.

-Тэгээд гүйцээ юү?

-Өөрөөр хэлбэл?

-Юу “өөрөөр хэлбэл”, “өөрөөр хэлбэл” гэж! хэмээн Альтманы уур дахин шатав. -Панкратовын хэргийн тухай таны мэдэх юм ингээд гүйцээ юү? гэж би танаас орос хэлээр асууж байна.

-түүний хэргийн тухайд би ерөөсөө юу ч мэдэхгүй. Баривч- лагдсаныг нь мэднэ, харин яагаад баривчлагдсаныг мэдэхгүй.

-Мэдэхгүй?! Юу ч мэдэхгүй гэнэ ээ! Цорын ганц онигоо мэднэ, энэ яваа насандаа цорын ганц онигоо ярьсан!

Альтман чимээгүй болж нэлээд удсанаа,

-Та Панкратовыг өмөөрч захиа бичсэн үү? гэж санамсаргүй асуулт тавив.

-Захиа, захиа... хэмээн Вадим бүр балмагдав.

-Тийм ээ, “захиа”, “захиа” шүү, Панкратовыг өмөөрч захиа бичсэн үү? гээд Альтман дахин шазвалзав.

Вадим Лена Будягины цайны өрөөнд сууцгааж байснаа нэхэн санав. Тэгэхэд Панкратовыг хамгаалж захиа бичих санал Нина тавьж байсан. Лена, Нина, Максим энэ тэр байсан... Сашаг аль уржнан баривчилсан болохоор Вадим түүнийг аль хэдийн мартжээ.

-Тэгэхээр ийм л дээ хэмээн Вадим итгэл муутай эхлэв. -Саша Панкратовыг баривчлагдсаны дараахан би манай ангийн Лена Будягиныд очсон, манай ангийнхнаас, өөр хэн хэн ч билээ, бас тэнд байсан...

Альтман үгийг нь тасдан,

-хэн бэ?! Яг хэн юм бэ? Марасевич, тодорхой яриач, битгий булзааруулж үг болгоныг надаар чангаалгах гээд бай гэж дүрэмдэв. -Та нөгөө үсчингээ бараг бүтэн жил болж байж санасан, цаашдаа ч ингээд байна гэж бодож байна уу? Үгүй шүү, бид танд хүний нэр болгон дээр жилийн бодох хугацаа өгөхгүй, таныг арай түргэн санадаг болгох арга бидэнд бий. Нэгдүгээрх нь гэвэл таныг энд үлдээх арга байна. Энд, хорих өрөөнд таны ухаан арай түргэн гүйх байлгүй.

Вадим толгой нь дүйнгэтэх мэт дүйрч, гар нь салганан, дэмий л санаа алдав.

-За, ярих уу? гэж Альтман гэнэтхэн тайван өгүүлэв.

-Ленагийнх надаас гадна Нина Иванова, Максим Костин хоёр байсан, бид цөм нэг ангийнх...

Альтман тэр нэрсийг цаасан дээр тэмдэглэж авав.

-Саша Панкратовын тухай ярилцсан. Саша Панкратовыг комсо-молын үнэнч шудрага гишүүн гэж бид мэдэх тухай Улс төрийн нэгдсэн газарт өргөдөл бичих санал Нина Иванова гаргасан. Би татгалзаж, түүнийг с у р г у у л ь д байхдаа комсомолын сайн гишүүн байсныг бид мэднэ, харин түүнээс хойш зургаан жил өнгөрсөн юм чинь яаж ч өөрчлөгдсөн байж мэднэ гэж хэлсэн. Лена Будягина...

-За, за, болно! гэж Альтман адгав. -Товчдоо бол, яллуулсан эсэргүүнийг яаж хамгаалах тухай асуудал хэлэлцсэн юм байна, Тийм биз дээ? Панкратовыг 58 дугаар зүйлээр ялласан бол тэр хувьсгалын эсэргүү мөн үү, биш үү, та юу гэж бодож байна?

Саша тэгэхэд дөнгөж баривчлагдаад ял заагдаагүй байсан, ямар зүйл ангиар яллагдахыг тэд нар мэдэхгүй байсан, тэгээд ч мань Вадим Ленагийн саналыг үнэхээр эсэргүүцэж байсан энэ тэр гээд Вадим тайлбар хэлбэл хэлэх л дээ. Гэвч мань хүн Альтмантай сөргөлцөхөөс айж, дахиад галзуу юм шиг хилэгнэх вий хэмээн үгийг нь дуулгавартай дагав.

-Мөн байлгүй яахав, Панкратовыг хувьсгалын эсэргүү гэж ялласан юм бол эсэргүү л байж таарна, эргэлзэх юм алга.

-Тэгвэл та нар хувьсгалын эсэргүүг хамгаалах гэсэн байна.

-Гэхдээ би хувьдаа...

-Юуны чинь “би хувьдаа”, “би хувьдаа” гэж... Та нар дор бүрдээ юу ярьсан чинь надад падгүй. Надад баримт л чухал. Та нар дөрвүү-лээ, өөрөөр хэлбэл, б ү л э г хүн цуглаж, баригдсан эсэргүүнд я а ж туслах тухай асуудлыг хэлэлцсэн байна. Явуулсан уу?

Вадим чухамхүү мань хүн татгалзсан учраас захиа явуулаагүй гэж хэлбэл хэлэх л дээ. Гэвч мань хүн худлаа ярихаасаа ухаангүй айжээ. Альтман түүний худлаа хэлснийг илчилчихвэл бүр долоон дор юм болно гэж бас ухаангүй айв. Тэгээд мань хүн ингэж хэлэв:

-Би хувьдаа татгалзсан, бид нар тэгээд Ленагийн ааваас, Иван Григорьевич Будягинаас зөвлөлгөө авсан, Оржоникизегийн орлогч, та мэдэх байлгүй, тэр бидэнд тийм захидал явуулах хэрэггүй гэж хэлсэн.

-За тэр шүү, одоо их бага ч гэсэн эрхбиш тодорхой боллоо, мэдээж, бүх юм биш л дээ, гэхдээ л зарим нэг зүйл тодорхой боллоо гэж Альтман сэтгэл ханамжтай өгүүлэв.

Тэрээр байцаалтын хуудсаа өмнөө дэлгэж, үзгээ аваад прото-колоо бичиж эхлэв.

Вадим эсрэг талд нь эвгүй хөдөлчихөөс болгоомжлон бэмбэгнэж сууна.

Альтман эхлээд Эльсбейн, Ершилов, Сергей Алексеевич энэ тэрийн нэр бичсэн цаасыг, дараа нь Лена, Нина, Макс гурвын нэр бичсэн цаасыг шагайж байгаад зөндөө удаан бичлээ.

Энэ нэр бүхий залуусыг, ер нь түүний нэрлэсэн бүх хүнийг одоо ийш нь дуудаж мэднэ гэдгийг Вадим ойлголгүй яхав. Тэгээд юу гэж? түүний сэтгэлд сэв алга. мань хүнийг дуудаад байцааж байгаа юм чинь тэднийг яагаад тэгж болохгүй сэн билээ? мань хүн ганц ч худлаа үг хэлээгүй, хэнийг ч муулаагүй, хэнээс ч урван тэрслээгүй, болсон юмыг болсон чигээр нь л хэлсэн. Тэднийг дуудах юм бол тэд нар ч гэсэн байсан юмыг байснаар нь л хэлэг л дээ. мань хүн юуны төлөө, хэний төлөө гэж өөрийгөө золиослох ёстой билээ? Үгүй шүү, мань хүн өөрийгөө золиослохгүй, тэд нарт ч гэсэн өөрсдийгөө золиослох шаардлага байхгүй, үнэнээ л хэлцгээнэ биз, тэгэхэд юу ч болохгүй шүү дээ.

Альтман сая нэг бичиж дуусаад протоколоо Вадим руу сарвайв.

-Унш даа, би зөв бичиж үү?

Вадим уншиж эхлэв. Бүх юм зөв бичигдсэн хэрнээ ерөнхий зураг нь аймшигтай юм болжээ. Эльсбейн Ершиловын дэргэд Вадимд онигоо ярьсан, мань хүн түүнийг өөрийнхөө үсчин Сергей Алексее-вичид ярьж өгсөн. Сергей Алексеевич яриа болгондоо Троцкийг илт талархан дурдана. түүний үгийг Троцкийн эсрэг чиглэсэн бүх яллага ямар ч үндэсгүй гэж ойлговол зохино. Баригдсан эсэргүү Панкратовыг хамгаалсан өргөдөл бичих саналыг Нина Иванова дэвшүүлсэн. Энэ асуудлыг ардын комиссарын орлогч И.Г.Будягины гэрт мань Вадим, Нина Иванова, Елена Будягина, Максим Костин нар хэлэлцэж Ардын комиссарын орлогч И.Г.Будягины шийдвэрээр уг өргөдлийг явуулаагүй.

Вадим цаашлан унших тусам гол руу нь улам хүйтэн оргиод байв. “Сергей Алексеевич Троцкийг илт талархан дурдана...” Сергей Алексеевич явж явж мэдээчин байх (түүнийг өрөвдөх юм алга), гэхдээ Троцкийг “талархан” дурддаг гэж Вадим зүтгэж чадахгүй, харин дооглонгүй хэлдэг байсан гэвэл өөр хэрэг. Бас “өргөдлийг” хэлэлцсэн... “Будягины шийдвэрээр”. Энэ чинь ямар нэг байгуул-лагатай төстэй юм биш үү. Гэхдээ яаж тайлбарлахаас болно.

-За, наана чинь юу нь сэтгэлд чинь таарахгүй байна? Зөв бичлэгийн болон найруулгын нарийн ширийн зүйлийг анзаарах хэрэггүй гэдгийг зөвлөө. Тэр чухал биш. Хэргийн гол нь чухал хэмээн Альтман зөөлөн дуугаар зугуухан айлдав.

Вадим түүнээс тийм үг сонсоно чинээ даанч санасангүй. Альт-маныг тиймэрхүү үгсийг огт мэдэхгүй гэж бодсон чинь мэддэг байх нь. түүний сэхээтний шинжийг мань хүн яагаад олж харсангүй вэ?

Альтман тэр хооронд үргэлжлэн ярьсаар.

-Та хэнийг аврах гээд байгаа юм бэ? Хэрэггүй. Наадуулын чинь

хэн нь ч гэсэн өөрийгөө хамгаалж чадна. Та итгэ. Харин та өөрийгөө ганцхан зүйлээр л аварч чадна: Энэ протоколд гарын үсэг зурснаар. Яагаад гээч? Яагаад гэвэл энэ зөв протокол.

Зөрвөл зүйтэй сэн. Гэвч зөрлөө гээд ямар ч ашиг байхгүй. Зөрснөөрөө Альтманы уурыг л шатаана. За яахав, ганц нэг үг өөрчлүүлэх юм биз, тэглээ гээд олз юу байна? Гол нь эндээс л гарах хэрэгтэй.

Вадим гарын үсэг зурж байхдаа Альтман гарыг нь яг дагуулан харж буйг мэдрэв.

Альтман хуудаснуудаа эмхлэн авч, өнгөрсөн удаагийн гарын үсэгтэй протоколтой нийлүүлэн хавтсаа хаан, ширээнийхээ шургуулганд хийгээд, сандлынхаа түшлэгийг гэдийн налж, Вадим руу шал өөр, найрсаг дотно харц илгээв.

-Вадим Андреевич, та сая юун дээр гарын үсэг зурснаа ойлгож байгаа биз дээ?

-Би шудрагаар зурсан.

-Тийм ээ, шудрагаар зурсан, би үүнийг чинь үнэлж байна.

Альтманы алуурчны сүүмгэр харц, адгуу овилгогүй зан алга болж, Вадимтай учир мэдэх амгалан сэхээтэн хүн ярилцаж байх шиг.

-Дахиад хэлэхэд, би үүнийг чинь үнэлж байна, таны утга зохиолын ажлыг өндөр үнэлдэг шигээ өндөр үнэлж байна. Камерын театрын тухай таны сүүлчийн өгүүллийг би өндөр үнэлсэн шүү. Тэр ч бүү хэл, гутарсан үедээ яаж ингэж бичсэн юм бол гэж бүр гайхсан гээч. Бидэнтэй танилцсанаас хойш та, мэдээж, гутарсан байж таарна. Бидэнтэй танилцахыг, яагаад ч юм бэ, аюултай гэж үздэг юм, тэр буруу шүү дээ, бидэнтэй танилцах чинь ашигтай. Өгүүллийн тухайд бол сайхан өгүүлэл байна лээ. Гэхдээ зарим нэг зүйл дээр зөрмөөр гэх үү, юу гэмээр юм бэ дээ, анхаармаар яль шаль юм байсан. Чухамдаа агуулгын талаасаа биш, хэлбэрийн талаасаа тэр шүү дээ. Гэвч гол юм энэ биш. Гол юм нь өөр зүйл бий: Би таны оронд байсан бол Коонентой хийсэн ярилцлаганаасаа яаж ийгээд хөндийрнө.

Ингэж хэлээд Вадим руу харав.

Вадим ч мэл гайхаж, цэл хөхөрч. Альтман өөрийнх нь далан булчирхайг ингэж мэдэхийн чинээ даан ч санасангүй.

Мундаг сэтгэгдэл төрүүлсэндээ баярласан Альтман цааш нь ийн үргэлжлүүлэв.

-Би яагаад тэгж бодож байна гээч? Манайд чинь увайгүй амьтад одоохондоо элбэг байгаа, танд атаархдаг хүн ч олон бий. Тэднүүс чинь Марасевич жил хагасын өмнө нэг юм бичиж байсан, одоо шал өөр юм бичиж байна гээд гоочлоод эхлэнэ. Тийм довтолгооноос сэрэмжлэвэл зүй. Та өөрөө ярилцлагаа эргэн санаж, одоо театрыг буруушаагаад буй гажиг дутагдал жил хагасын өмнө ч байсан

гэдгийг харуулах ёстой байсан юм. Гэтэл та тэгсэнгүй.

Тэрээр энэ удаа Вадим руу арай хачирхам байдлаар харав.

-Тэгвэл зүгээрсэн. Таныг энэ театрыг шагшин магтаж байх үед азарган тагнуул, алан хядагч

Пикель захирал нь байсан шүү дээ. Та сонин уншдаг хүн, Пикелийг юуны учир буудан алсныг мэдэх байлгүй?

-Би түүнийг чинь таних ч үгүй шүү гэж Вадим бувгнав.

-Вадим Андреевич, үүнийг чинь батлах шаардлагатай зүйл, гэтэл батлахад хэцүү дээ. Та Камерын театраас салдаггүй хүн, тэдний орон тооны шүүмжлэгч ч гэж хэлж болно, тэр ч байтугай, тавдугаар эгнээнд та тусгай суудалтай. Гэтэл та театрын захирлыг танихгүй байх нь уу?

-Гэхдээ, би нээрэн...

-За яахав хэмээн Альтман түүний үгийг тасдаж, -Пикелийн тухай ярихаа больё, театрын тухай ч, урлагийн тухай ч ярихаа больё, эс тэгвэл энэ мэтгэлцээнээр та бид хоёр хадуураад арилж өгнө гээд нүдэнд дулаахан, сэтгэлд урамтай инээв. -Та юу юуг хүлээн зөвшөөрснөө өөрөө сайтар ойлгосон байгаасай гэж хүсч байна. Нэгд, таны дэргэд зөвлөлтийн эсрэг онигоо ярьсан. Та үүнд ямар хариу өглөө? Манайд ирсэн үү, үгүй ядахдаа намын хороондоо болсон явдлыг мэдээлж, зөвлөлтийн эсрэг үзэлтнийг илчилсэн үү? Үгүй, тэс эсрэг юм хийсэн. Та өөрөө тэр онигоог тарааж эхэлсэн. хэнд билээ? Өөрийнхөө үсчинд. Зөвхөн ганц түүнд үү? Зөвхөн түүнд гэж та зүтгэж байгаа. Танд итгэх үндэс бидэнд байхгүй. Нэг хүнд ярьсан юм чинь өөр хүнд яриагүй гэхийн газаргүй. Гэхдээ, ямар ч аугай, та энэ онигоог сонссон, хэнээс сонссоныг бид мэднэ, бас хэнд ярьсныг бид мэднэ, Энэ санамсаргүй зүйл үү? Санамсаргүй зүйл гэж бий, санамсаргүй нэг юм сонсож болно, хэн нэгэнд санамсаргүй ярьчихаж болно, энэ бол байдаг зүйл, тэглээ ч гэсэн бид өршөөхгүй, яагаад гэвэл юу ярьж байгаагаа хүн ойлгож байх ёстой. Гэхдээ, таны хувьд бол, Вадим Андреевич, санамсаргүй зүйл биш, огт биш шүү.

Альтман Вадим руу харж, харц нь дахин яльгүй сүүмийхэд мань хүн айсандаа болоод зүрх нь палхийгээд явчихав. Тэгснээ Альтманы харц хэвийн болж яриагаа үргэлжлүүлэв.

-Яагаад санамсаргүй биш вэ? Яагаад гэвэл, Вадим Андреевич, та нууц троцкийчуудын нэг.

Вадим жигтэйхэн дургүйцэн тунтганахад Альтман гараар өргөн зангав.

-Тайван, тайван бай! Та нар бүлэглэн цугларч, баригдсан эсэргүүг хамгаалах зорилготой захидлын тухай хэлэлцэж байсан. Тийм захиаг эсэргүүцсэн гэж та хэлж байгаа. Танд итгээд эсэргүүцсэн юм байж гэж саная. Тэгвэл та яагаад эсэргүүцэв? Эсэргүүг хамгаалж болохгүй учраас тэр үү? Үгүй ээ. Сургууль төгссөнөөс хойш их удсан учраас гээ биз дээ. Энэ зөвлөлт маягийн хандлага уу? Биш, зөвлөлт маягийн хандлага шал өөр байр суурьтай байхыг шаарддаг: Баригдсан эсэргүүг би хамгаалахыг хүсэхгүй, хамгаалах ч үгүй, тэр тухай хэлэлцэхийг ч хүсэхгүй гэдэг байр суурь. Энэ бол зөвлөлт маягийн хандлага. Та тийм хандлагатай байгаагүй. Тэр битгий хэл, та энэ асуудлыг хэлэлцэхэд оролцсон, хэрвээ Будягин хориглоогүй бол тэр захианд гарын үсэг гарцаагүй зурах байсан даа. Будягин яагаад хориглосныг та бас л мэдэхгүй. Та иргэнийхээ сэтгэлийг удирдлага болгоогүй, хэн нэгийн тушаалыг дагасан. Таны энэ байр суурь, тэгэхээр, ямархан хөрсөн дээр бүрэлдэн тогтсон байхав? түүний үндэс таны өсч бойжсон нөхцөл байдлаас улбаатай. Та гадаадынхан өөрийн

хүн шиг байдаг айлд өссөн. Профессор Крамер, Россолини энэ тэр гэнэ, (Альтманы дуунд жигшсэн өнгө илт), ээ бас мундаг аа... Тэд нар бидэнд үнэнч гэдэгт та итгэж байна уу, тэд нар манай руу зөвхөн шинжлэх ухааны зорилгоор ирж очдог гэдгийг та батлан даах уу? Чадах уу?

Вадим дуугарч ч чадахгүй уруу царайлна.

-Чадахгүй гэж Альтман төлөөнөөс нь хариулав. -Гэтэл та тэдэнтэй нэг ширээний ард сууж, идэж, ууж, тэдний яриаг сонсож байсан хэрнээ нэг ч удаа бидэн дээр ирж, манайд гадаадынхан болохгүй юм яриад байна шүү гэж мэдэгдээгүй. Танай дүү чинь тэдний нэгэн болох зартай зөвлөлтийн эсрэг үзэлтэнтэй суусан. Тэр этгээд зөвлөлтийн эсрэг үзэлтэн төдийгүй тагнуул, даанч амжаад зугтчихсан, шүүх цаазнаас мултарч дөнгөсөн. Ганцаараа зугтаагүй, дүүгий чинь аваад явчихсан, бас санамсаргүй биш байлгүй. Парист хөөрхөн хүүхнүүд мундаа юу? Мундахгүй. Ингэхэд, түүний сүйт бүсгүй танхай баян айлын охин, гэтэл тэр этгээд эс тоож танай дүүг илүүд үзсэн байгаа юм. Яагаад үл тоохдоо хүрснийг би танд хэлье. Танай дүүг эндээс амжуулж авч гарах гэсэндээ тэр. Тийм, яг тийм шүү. Дүү чинь энд булхай нь бултайх гэгчдээ хүрсэн хүн, тийм учраас мань хүнд түүнийг гаргаж аврахыг тушаасан, мань хүн ч гаргаж аварсан нь тэр.

Альтман чимээгүй болж, гохигор гэдсэн дээрээ гараа салаавчлан, Вадимын хажуугаар гуниглан харж хэсэг суув.

-Вадим Андреевич, ийм л зангилаа үүсчихээд байна, таны хувьд тун тусгүй зангилаа. Ер нь бол нөхөр Сталины тухай ганц онигооны чинь төлөө таныг аль хэдийн шоронд хийвэл зохих юм... Гэтэл онигооноос гадна бас гадаадынхан байна, бас баригдсан эсэргүү-нүүдийг хамгаалах оролдлого байна. Ийм байхад, Вадим Андреевич, бид таныг шоронд хийсэнгүй, харин ч өршөөгөөд байна... Яагаад тэр вэ? Шуудхан хэлэхэд, бид таныг үнэлж байгаа юм. Таны өгүүлүүдээс үзвэл та зөв байр суурин дээр байна. Гэтэл нэг асуулт бий: Чин санаанаасаа тийм байна уу, эсвэл тийм дүр эсгэж байна уу? Энэ хэргээр жишвэл гээд Альтман протокол хийсэн ширээнийхээ шургуулга руу дохиж, -бид эргэлзэж болохоор байна, тэгж эргэлзэх олон шалтгаан энд бий. Тэгэхээр, та чин санаагаа бидэнд нотлох ёстой. Байдал ийм л байна, та юу гэж үзэж байна, Вадим Андреевич? хэмээн түүн рүү тун нухацтай харлаа.

Вадим дал мөрөө хавчив.

-Мэдэхгүй... Ийм л хачин юм болчихож...

-Вадим Андреевич, та хэрхэхээ маш сайн бодох хэрэгтэй.

-Өө, тэгэлгүй яахав, хойшид би тун болгоомжтой байя гэж Вадим өчив.

-За, зүйтэй, болгоомж гэдэг бол сайн зүйл, гэхдээ үүнийг яахав? гээд Альтман дахин ширээний шургуулга руу дохив. -Би удирд-лагадаа юу гэж илтгэх вэ? Удирдлага энэ хэргийг уншмагц надаас “Энэ Марасевич аль өрөөнд хоригдож байгаа вэ?” гэж асууна. Би түүнд юу гэж хариулахав? “Тэр болгоомжтой байна гэж амласан” гэж хариулах уу? Тэгэх юм бол таныг хорих ёстой өрөөнд намайг өөрийг маань хорьчихно. Гэтэл би хоригдохыг хүсэхгүй байна,

ёстой хүсэхгүй байна, Вадим Андреевич минь.

Тэрээр дахиад дуугүй болов.

Вадим айгаад хөдлөж ч чаддаггүй. Шар нь дүүрч байгааг хэлэх үү, уул нь соод уучихвал зүгээр, мань хүн соод дандаа авч явдаг юм чинь. Гэвч айгаад ус гуйж зүрхэлдэггүй.

-За, тэгэхээр, Вадим Андреевич, хоюулаа дуусгах тийшээ хандъя гэж Альтман гэнэтхэн хөгжилтэй өгүүлэв. -Дахин хэлэхэд, та чин санаагаа бидэнд нотлох ёстой. Хэрвээ та нотлох юм бол энэ бүхэн хэмээн ширээний нүд рүү тогшиж, -үнэхээр утга учиргүй санамсаргүй зүйл болж хувирна. Та намайг ойлгов уу, Вадим Андреевич? гэж асуув.

-Өө, тэгэлгүй яахав, мэдээж.

мань хүн өөрөөс нь юу шаардаж буйг сайтар ойлгож байв. Тэдний шаардлагыг зөвшөөрнө гэдгээ бас ойлгож байвч, тийм үгсийг өөрөө хэлэхээс аргагүй хулчийжээ.

-Юуны чинь “өө” гэж, та юу ойлгосон юм бэ? гэж Альтман хөмсөг зангидав.

-Чин санаагаа нотлох ёстой гэдгийг би ойлголоо.

-Яаж нотлох юм бэ?

-Мэдэхгүй байна... Би бэлэн. Гэхдээ... Мэдэхгүй байна.

-За тэгвэл, би танд хэлж өгье. Нам, улсын дайснуудтай тэмцэхэд бидэнд та туслах ёстой гэж Альтман эрсхэн хэлэв.

-Харин миний өгүүлэл, миний хийдэг яриа, лекц...

-Таны өгүүлэл, яриа таниулгыг бид мэднэ, би энэ тухай түрүүн танд ярьсан. Тэд чинь утга зохиол, урлагт хамаатай зүйл, харин бид бол утга зохиол, урлагийн х ү м ү ү с и й н тухай мэдэхийг хүсч

байна. Тэд чухам хэн болох, тэдний ж и н х э н э санаа бодол нь юу болох, үнэн хэрэгтээ юун тухай бодож байгаа, индрээс бусад газар юу ярьдаг энэ тэрийг бид мэдэхийг хүсч байна. Бидэнд туслагч хэрэгтэй.

-Бололгүй яахав...

Альтман ширээнээсээ нэг хуудас цаас гаргаад, үзгээ Вадимд өгөв.

-За бич!

-Юу бичих билээ?

-Та бидэнд туслахад бэлэн гэдгээ.

-Харин би туслана л даа, бичихийн хэрэг юу байна?

-Би дээш нь юу гэж илтгэхэв? Туслана гэж ц э э ж э э р амласан гэх үү?

Тэрээр шургуулгаа татаж протоколтой хавтсыг гаргаж ирээд ширээн дээр шидэв.

-Энд таны муу явдлууд бичээтэй байгаа, сайн явдлыг та бичих хүсэлгүй байх шив. Аман дээрээ болохоор туслах ухааны юм хэлдэг хэмээснээ Альтман цагаа харж, -За таныг албадсан хүн ер байхгүй, өөрөө шийд. Та бид хоёр хоёр цаг гаруй хэл амаа билүүдлээ. Надад бас өөр ажил бий гэдгийг та эрхбиш ойлгож байгаа байх гэж дүрэмдэв.

Вадим үзгээ бэхэнд дүрэв.

-Би юу бичих ёстой юм бэ?

Тэрээр нэгэнт үнэ цэнээ мэдсэн гэлтэй тайван, нэр төртэй гэмээр ингэж асуужээ.

Альтман тогтуухан хэрнээ итгэл төгс эрсхэн дуудаж эхлэв:

-“Дор гарын үсэг зурсан иргэн Вадим Андреевич Марасевич миний бие, Зөвлөлт засагт хор хүргэх аливаа ам яриа болон хэвлэмэл зүйл, үйлдлийн талаар ДЯАК-ын байгууллагад мэдэээлж байх үүрэг авч байна. Түүнчлэн ДЯАК-ын байгууллагуудын заалтаар утга зохиол, урлагийн бүтээлийн талаар тэдэнд зориулан шүүмж бичиж байх үүрэг авч байна”. Биччихэв үү? За ингээд гүйцээ. Энэ бүхнийг өөрийнхөө гарын үсгээр бичиж бай гэж бид албадахгүй. Юу эс тохиолдохыг тэр гэхэв. Гээчихэж мэднэ, аль нэг газар мартчихаж мэднэ, тэгвэл хэн нэгэн олчихно, бид танд элдэв төвөг удахыг хүсэхгүй байна. Тийм учраас мэдээллүүдээ нууц нэрээр ирүүлж байх нь хамаагүй дээр. Эрэгтэй хүний нэр ч болно, эмэгтэйнх ч болно. Эмэгтэй нууц нэр байвал таныг доромжилсон болохгүй биз дээ?

Мөн алиалах юмаа олж ядав аа, тохуурхах санаатай байх нь.

-Эрэгтэйнх дээр гэж Вадим өчив.

-За тэгье... Таны нэр Вадим... Вацлав гэх үү? Вацлав болж байна уу?

-Болно.

-Гүйцээгээд биччих: “Мэдээллээ Вацлав гэдэг нэрээр өгч байна”. Биччихэв үү? Одоо гарын үсгээ зурчих... Зүйтэй. Бас сар, өдрөө тавьчих. Өнөөдөр хэдэн билээ?

Сталин өглөөний цайныхаа өмнө цэцэрлэг рүү гарч зөргөөр хэсэг алхав.

Намуу цэцэг дэлбээлчихэж. Цагаан, цэнхэр, хүрэн ягаан манжхуй цэцэг ногоон зүлгэн дээр тун зохьсон гэлтэй. Нэлээд цаахнуур өндөр шилбэтэй, дунд хэрд нь хар цаасаар боочихсон нэр үл мэдэх цэцгэс сэхээвчний тэндээс илхэн харагдана. Цэцгэн дээр цаасны хэрэг юу байна?.. Хар цаас нь юу ч билээ дээ? Харахад зэвүүн гэж.

Үйлчлэгч Валя өглөөний унд оруулж ирэв.

Тэрээр түүнийг хуруугаараа дохин сэхээвч рүү дагуулж очоод цэцэг рүү заав.

-Энэ юу гээч вэ?

Валя инээд алдан,

-Иосиф Виссарионович, энэ чинь арилд цэцэг. Доод цоморлиг нь дээдхээсээ түрүүлж дэлбээлдэг юм. Зэрэг цэцэглэсэн нь харахад их гоё. Тийм учраас дээдхийгээ дэлбээлэхээс өмнө доодох нь гандчихвий гэж ингэж хар цаасаар ороодог юм. Зубаловод ч бас ингэдэг байсан...

Тэрээр Зубаловын тухай дурсахыг Власик хориглосныг гэнэтхэн санамагц дотор нь палхийн чимээгүй болжээ.

Сталин хариу юу ч дуугаралгүй, Валя руу ууртай харснаа өрөөндөө эргэж ирж, өглөөнийхөө унданд гар ч хүрэлгүй, шинелиэ нөмрөөд жижиг хаалга руу зүглэв.

Доголон нулимстай Валя араас нь балмагдан харж зогсохдоо Иосиф Виссарионовичийг өрөвджээ. Ямар хар нүгэл вэ, санаандгүй байж байгаад түүнийг гомдоочихлоо, өглөөний цайгаа уулгүй явах чинь ямар сайн байхав, ээ бас тусгүй юм боллоо... Ямар ороолон шүглэж байгаад Зубаловог дурсуулчихав аа...

Машин Можайскийн засмал руу ордог нарийхан замаар явж байна. Сталин жолоочийн хажууд сууж яваа хурандаа, зам дээр өмнө хойно нь гарч ирсэн хамгаалалтын хоёр машин энэ тэрийн алийг ч эс анзаарна. Тэрээр баруун талаар жирэлзэх гачуур, солгой талын хус, улиас руу хараачлана. Уул нь энэ төглийг хуу самнан шалгаж, далдаас битүү хамгаалж байгааг мань хүн андахгүй. Гэхдээ чухамхүү хамгаалалтынхан л духанд нь юм уу, шилэнд нь сум зоож мэднэ. Хамгаалагч болгон замыг хянаж байгаа төдийгүй зэрэгцээх хамгаалагчаа бас хянаж байгаа учраас ямар ч “санамсаргүй явдал” тохиохгүй гэж Паукер байнга андгайлж байгаа. Тэр муу зуйгуур Паукер “санамсаргүй явдал” гэж хэлсэн шүү. Тэглээ ч гэсэн замын хоёр талаас бараг шахан нөмөрсөн энэ ой нэг л биш, цаанаа л нэг түгшүүртэй санагдана.

Машин нь Можайскийн засмал дээр гарч, цаашлан Дорогоми-ловын гудамжаар хурдлах зуур Сталин овоо уужрав. Энд ард нь буутай хүн нуугдчих гачуур, хус, улиас байхгүй. Энэ бол гудамж, энд хамгаалалт нэгэнт жигдэрсэн байгаа, замын хөдөлгөөн ч хаалттай, эндхийн

мангаа нь хүний өөрийнх нь айдас...

Эртэн цагт эзэнтнээ гудамжаар явж өнгөрөхөд харьяат ардууд нь боол мэт номхон хүлцэнгүй б а й г а а илэрхийлэн газар мөргөн унаж, толгойгоо өндийлгөхгүй тэр чигээрээ хэвтэж байх үүрэгтэй байсан. Тэр бол номхон хүлцэнгүй буйг харуулах гэж зохиосон журам биш, харин аливаа халдлагаас сэрэмжилсэн арга, хэн нэгний толгой өндиймөгц тэр даруй хамгаалагчийн сэлмэнд өртөнө. Муугүй журам шүү. Эртний дээдчүүл олон түмнээс яаж хамгаалахаа аргагүй мэддэг байж. Харин ордны хуйвалдаанаас яаж хамгаалахыг тэр болгон мэддэггүй байсан...

Зиновьев, Каменев хоёрын амь насыг хэлтрүүлнэ гэсэн амлалтаа биелүүлээгүй нь мань хүний зөв үү, буруу юу?

Зөв.

Яагаад зөв байна вэ?

Яагаад гэвэл шүүн таслах ажиллагаа нам, улсын ашиг сонирхолд нийцэж байсан, яллагдагсад хэргээ хүлээсэн нь нам улсын ашиг сонирхолд нийцэж байсан.

Яллагдагсад гэмт хэргээ хүлээчихээд байхад тэднийг өршөөнө гэдэг бол хэргээ хүлээснийх нь үнэн магадад, аймшигт гэмт хэргийнх нь үнэн магадад эргэлзээ төрүүлнэ гэсэн үг.

Тэднийг өршөөнө гэдэг тийм аймшигт гэмт хэргийг уучилж болдгийг тунхаглана гэсэн үг.

Тэднийг өршөөнө гэдэг бол нам, улсад засахын аргагүй хор хохирол тарина гэсэн үг.

Виктор Гюго нэг удаа “гэмт хэрэгтэн эзэн хааны титэмтэй ч бай, тарчилагчийн хормогчтой ч бай, гэмт хэрэгтэн хэвээрээ үлдэнэ” гэж хэлсэн. Гоё мөртлөө франц маягийн хоосон үг. Гэмт хэрэгтэн хувийн сэдэлдээ хөтлөгддөг байхад эзэрхэн захирагч улсынхаа ашиг сонирхлыг удирдлага болгодог. Тийм учраас эзэрхэн захирагч хэзээ ч гэмт хэрэгтэн болохгүй, улсын ашиг сонирхолд юу нийцэх, юу эс нийцэхийг гагцхүү өөрөө шийддэг юм чинь.

Ленин үнэний тухай их ярьдаг, гагцхүү үнэнийг шаарддаг байсан. Ленин, мэдээж, их хувьсгалч байсан, гэхдээ, харамсалтай нь, ёс суртахуун, зан суртахууны тухайд өрнөдийн ойлголтоор хүмүүжсэн хувьсгалч байсан учраас зарим талаар хөрөнгөтний сэжиг сүжгээс салж чадаагүй хүн.

“хүний мөс” гэдэг бол хийсвэр хоосон ойлголт. “хүний мөс” гэдэг бол тэрсүүд үзлийн нуувч: “Би улс төрч биш, надад улс төрийн үзэл бодол байхгүй, зөвхөн хүний мөс л байна”. Тун зальжин, овгой томъёолол.

хүний мөс гэгчтэй хүмүүс бол аюултай хүмүүс. Тийм хүмүүс юу ёс суртахуунтай, юу ёс суртахуунгүйг өөрсдөө тогтоох эрхтэй гэж үзнэ. Тэгээд тэр эрхээ бүх юманд, тухайлбал, улс төрд хүртэл нялзаана. Тэд нар тэр хүнийн мөс гэгчээрээ нам, улсын үйлдлийг, өөрөөр хэлбэл, түүний үйлдлийг хэмжих санаатай. Тэд нар тэр хүний мөс гэгчээрээ халхлан

түүнийХЭЭС өөр илтгэл үнэмшилтэй байх юм гэнэ. Үүнийг үүрд таслан зогсоох хэрэгтэй.

Улс төр, сүсэг бишрэлийн итгэл үнэмшлийнх нь төлөө хэнийг ч шоронд хийж болохгүй гэж Маркс бичсэн удаатай.

Марксын гарт төрийн эрх мэдэл байгаагүй юм чинь тэгж бичих шиг амархан юм юу байхав. Маркс ч бас хөрөнгөтний сэжиг сүжгээс салсан хүн биш. мань хүний гарт төрийн эрх мэдэл байсан бол улс төрийн үзэл бодол түргэн зуур улс төрийн үйлдэл болж хувирдаг, тэрсүүд үзэлтэй хүн бодит дайсан болж хувирдагийг ухааралгүй яахав.

Ленин засгийн эрхийг булаан аваад түүнийгээ тогтоон барьж чадах намыг байгуулсан. Гэтэл улс түмний түүхэнд тийм нам бишгүй байсан. Харин засгийн эрхийг аваад хэсэг хугацаанд л тогтоон барьж байсан.

Тэрээр засгийн эрхийг үүрд барьж чадах намыг байгууллаа.

Тэрээр урьд хождын бүх намаас ялгаатай, цоо шинэ маягийн намыг байгууллаа. Энэ нам төр улсын бэлгэ тэмдэг төдийгүй улсын цорын ганц нийгмийн хүч мөн. Энэ намд харьяалагдах нь түүний гишүүдийн гол давуу чанар төдийгүй тэдний амьдралын утга, агуулга мөн. Тэрээр намынх нь хувьд намын үзэл санааг бурхан, ёс суртахуун, гэр орон, гэр бүл, зан суртахуун, нийгмийн хөгжлийн хууль гэхчилэн бүхнийг орлох нэгэн зүйл төгс шүтээн болгож бүрдүүлээ.

Хүн төрөлхтний түүхэнд тийм нам байгаагүй. Тийм нам бол төр улс, түүний төр улс бат оршихын баталгаа.

Хэрвээ нам төгс шүтээн юм бол түүний жолоодогч бас төгс шүтээн.

Намын жолоодогч л чухамдаа тэр намын ёс суртахуун, зан суртахууны эрхэмсэг биелэл мөн.

Тэгэхээр түүний хийж буй бүхэн ёс суртахуун, зан суртахууны алинд ч харшлахгүй. Өөр ёс суртахуун, зан суртахуун гэж байхгүй, байх ч ёсгүй. Ёс суртахуун ч, зан суртахуун ч төрд үйлчилж, төрийн ашиг сонирхол, түүний зорилтод нийцэж байх ёстой.

Одоогийн гол зорилт бол боловсон хүчний хувьсгал. Одоогийн болоод ирээдүйн дайсныг устгахын тулд юуны өмнө урьдын дайсныг устгах хэрэгтэй.

Бородиногийн гүүр рүү гарцгааж явна. Сталин энэ гүүрийг их таалдаг билээ. Нүсэр сүрлэг, аргагүй гоё хийцтэй гүүр. Чухамхүү ингэж л барих ёстой. Гэтэл одооны хэлбэрдэгч уран барилгачдын бүтээл гэж ямар ч царай зүсгүй, эв хавгүй хайрцагнууд.

Смоленскийн талбай өгсөж Арбат руу орж ирлээ.

Сталин дахиад бодлогошров.

За ингээд эхний шатыг давлаа, эхний шүүн таслах ажиллагаа дууслаа, шүүгдэгсэдийг буудан аллаа.

Энэ шүүх ажиллагааны сургамж юу вэ? Ямар ч байсан гарцаагүй зөв болж таарлаа. Зиновьев, Каменев хоёрыг үүрд эцэс болголоо, бие хүний хувьд ч, улс төрийн хувьд ч. Энэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт, саяны шүүн таслах ажиллагаан дээр Пятаков, Радек, Сокольников, Серебряков болон бусад троцкийчуудын нэр гарлаа. Тэд нар хэдийн баривчлагдаж, тэдний харьяалагдаж байсан “Зэрэгцээ төв”-ийн хэргийг мөрдөн байцаах ажил ид явж байна. Гэтэл зөвхөн алан хядлагаар яллах нь хангалтгүй. Тэгж яривал алан хядлага бол тэмцлийн нэг л хэлбэр. Марксистууд энэ хэлбэрийг ёс суртахуунд харш учраас бус, үр дүн муутай учраас хүлээн зөвшөөр-дөггүй юм. Харин эсөрүүд алан хядлагыг үр дүнтэй гэж үзээд хэрэглэж ирсэн. Ардын зоригийнхон бас хэрэглэдэг. Хувь хүнийг алан хядах явдал оросын хувьсгалт хөдөлгөөнд эртний бөгөөд гүнзгий үр үндэстэй.

Энэ сэдвийг дэврээх юм бол залуучуудын ухамсарт шингэчихэж мэднэ. Дуурайх амьтад ч олдоно. Тийм байдалд хүргэж болохгүй. Тийм учраас “Зэрэгцээ төв”-ийнхөнд алан хядлагаас илүү ноцтой ял тулгах ёстой.

Гуравдугаарт, Бухарин, Рыков, Томский, Угланов болон бусад баруунтны нэр гарлаа, өөрөөр хэлбэл, тэднийг ч бас шүүх үндэс бүрдлээ.

Томский шүүх хурал дээр нэр нь дурдагдсаны дараа наймдугаар сарын 22-нд Болшевийн зусландаа өөрийгөө буудаж алсан. Төв Хороо энэ явдлыг буруушаасан. Гэтэл Томский амиа хорлосноороо түүний эсрэг, тэгснээр нийт бухаринчуудын эсрэг тулгасан ял ноцтой байсныг л зөвхөн нотлосон хэрэг.

Дөрөвдүгээрт, цэргийнхний, тухайлбал, корпус командлагч Путна, Примаков, дивиз командлагч Шмидт нарын нэр гарч тэд баривчлагдлаа, ингэснээр Тухачевскийн толгойлсон цэргийн хуйвалдагчдыг устгах үндэс бүрдлээ.

Энэ бол шүүн таслах ажиллагааны эерэг сургамж. Сөрөг сургамж бас байна. Гол нь бэлтгэл сайн хангагдаагүй, зарим жижиг сажиг зүйлийг гүйцээж бодоогүй будлиулсан зэргээс болоод муу зальхай Троцкийд хөрөнгөтний хэвлэлээр дамжуулан няцаан үгүйсгэх шуугиан дэгдээх боломж олгосон.

Ийм шуугиан дэгдэх нь мэдээж байсан, гэхдээ Гольцман дээр

гаргасан алдаа бол тэсвэрлэшгүй зүйл. Яллагдагсадыг буудан алснаас хойш, яг долоо хоногийн дараа Данийн засгийн газрын албан ёсны хэвлэл “Социалдемократен” нэг мэдээ нийтлэсэн: Гольцман Седовтой уулзаад тэндээсээ Троцкий руу явсан гэж мэдүүлсэн “Бристоль” зочид буудлыг аль 1917 онд нураасан бөгөөд Копен-гагенд “Бристоль” нэртэй өөр зочид буудал байхгүй.

Энэ бол том алдаа. Энэ бол шүүн таслах ажиллагааг харлуулах гэж Ягодын хийсэн ажил.

Гольцманыг Троцкийтэй уулзуулах санааг мань хүн хэлсэн нь үнэн, гэхдээ байхгүй зочид буудлыг яагаад сонгов, ер нь яах гэж зочид буудлыг бодож олов? Тэд нар галт тэрэгний буудал дээр уулзсан гэж Гольцман хэлж болох байсан. Тэр чинь Троцкийтэй уулзах гэж л Берлинээс

Копенгагенд очсон гэж мэдүүлсэн шүү дээ. Тэгвэл Седов түүнийг галт тэрэгний буудал дээр тосч уулзаад л аав руугаа аваад явж болно биз дээ.

Ийм тодорхой, ийм хялбархан зүйл. Тэгэхэд чинь үгүй шүү, буудал, зүгээр ч үгүй огт байдаггүй буудлыг бодож олсон байгаа юм. Ийм алдаа цаашдаа давтагдах ёсгүй. Ягода ч бас цаашдаа байх ёсгүй.

Ягода “Бристоль”-ийн тухайд гаргасан алдаагаа Сталинд тайлбарлаж сууна. Тэдний нэг ажилтан Копенгаген, Осло хоёрын зочид буудлын жагсаалтыг хооронд нь сольж будлиулсан, Ослод “Бристоль” гэж буудал бий. Тэр ажилтныг хатуу шийтгэсэн гэж Ягода илтгэв.

-Яаж шийтгэсэн бэ? гэж Сталин асуув.

-Цолыг нь бууруулж, Хорихыг удирдах газарт шилжүүлсэн.

Сталин түүн рүү тугалган харцаар харав.

-Энэ бол шүүн таслах ажиллагааны нэр хүндийг унагах тооцоотой, зориуд хийсэн хорлон сүйтгэх үйлдэл. Буруутныг нь Цэргийн шүүхэд шилжүүлвэл зохино. түүнийг ийм алхам хийхэд хүргэсэн хүмүүсийг бас Цэргийн шүүхэд шилжүүл.

-Мэдлээ, гүйцэтгэе гэж Ягода хариулснаа, -Гэхдээ тэр ажилтан, овог нь Дьяков... гэтэл Сталин түүний үгийг тасдав.

-Намын даалгавар тасладаг хорлон сүйтгэгчдийн нэр надад сонин биш.

-Мэдлээ, гүйцэтгэе хэмээн Ягодын уруул татваганав. -Энэ ажилтан Копенгаген Осло хоёрын зочид буудлын жагсаалтыг андуурч тэр алдааг өөрөө л гаргасан.

-Өөрөө... хэмээн Сталин Ягода руу харав. Өөрснийхнийхөө аминд орж, цохилтоос аварч байх нь... -За яахав, ганцаараа бүгдийн өмнөөс хариуцлага хүлээг.

Сталин дуугүй азнасхийснээ,

-Мэдүүлэг өгөөгүй троцкийчуудыг хаана барьж байна? гэж асуув.

-Одоохондоо эндшээ, Москвад.

-Бүгдийг нь дахиад байцаа, дахиад мэдүүлэг өгөхөөс татгазсан хэнийг ч болов алан хядагч гэдгээр Цэргийн шүүхэд шилжүүл. Шүүхийн шийдвэрийг мэдээлэх хэрэггүй. Нэг ч удаа бууж өгөөгүй идэвхтэй троцкийчуудын хувьд гэвэл тэд хорих лагерийн байрыг чөлөөлвөл таарна. Хорих лагерьт ч бай, шоронд ч бай, цөллөгт ч бай, Зөвлөлтийн газар нутаг дээр тэдэнд зай байхгүй. Зөвлөлтийн ард түмнийг тэднээс чөлөөл.

-Мэдлээ, гүйцэтгэе хэмээн Ягода уруул нь чичирсэн хэвээр өчив.

-Эдгээр хүмүүс бол намын дайсан, зөвлөлт улсын дайсан, үүрдийн дайсан. Смирновын шүүх

дээр авирласан байдал үүнийг тов тодорхой нотлосон, ер нь ч тэр этгээд шүүхийг гутаах гэж л шүүх хуралд оролцсон. түүний талынхан үүний хариуцлагыг хүлээг. Бол оо! Бараг арван жил тэдэнтэй зууралдаж байна. Зөвлөлт засгийн заналт дайснуудыг хооллохоос арай чухал ажил манай улсад бий.

-Мэдлээ, гүйцэтгээ.

Сталин хямсайв: Энэ муу өөрөө хариуцлага хүлээхээс айж байх нь, бичиг цаасгүй, протоколгүй, хэрэг хүлээлгэлгүй, албан ёсны юмгүй хийхээсээ айж байх нь.

-Ял заахын тулд хүмүүст Онцгой зөвлөлгөөний бүрэн эрхт төлөөлөгчийн эрх олгон хорих ангиудаар явуул.

Сталин тугалган харцаараа Ягодыг дахин нэвт цоргив. Тэнд очоод арга бааш хэрэглэж, өөрсдийгөө зөвтгөх элдэв цаас бэлтгэнэ гэж горьдож байгаа вий. Үгүй, гайгүй байлгүй.

-Ямар ч байцаалт хэрэггүй, ямар ч ял тулгах хэрэггүй. Хорих ангийн дарга нар хориход эсэргүү үйл ажиллагаагаа, троцкист яриа явуулгаа, зөвлөлтийн эсрэг хэл өгүүллээ үргэлжлүүлж байгаа троцкийчуудын нэрсийн жагсаалтыг гаргаг. Тэр жагсаалтынх нь дагуу ял заах хэрэгтэй. Тэгээд ялыг нэн даруй ёсоор болго.

-Мэдлээ, гүйцэтгээ хэмээн Ягода дуулгавартай өчив.

Сталин түүн рүү муухай харсан чигээрээ,

-Сүүлчийн зүйл хэмээгээд, -“Зэрэгцээ төв”-д оролцогчид засгийн эрхийг булаан авахын тулд алан хядах ажиллагаанд оролцсоноо хүлээгээд зогсохгүй, фашист Герман, милитарист Японд нутаг дэвсгэрийн ихээхэн буулт хийж, жишээлбэл, Германд Украиныг, Японд Алс Дорнодыг өгөх замаар, тэдний тусламжинд дулдуйдан Зөвлөлт Холбоот Улсад капитализмыг сэргээн тогтоох санаатай байснаа хүлээх ёстой гэж айлдав.

Түр дуугүй болсноо,

-Та зорилтоо ойлгов уу? гэж асуулаа.

-Ойлголгүй яахав гэж Ягода бачимдан хариулав.

-Та энэ зорилтыг биелүүлж чадна гэж найдаж болох уу?

-Бололгүй яахав гэж Ягода санаандгүй эрсхэн өчив.

Уруул нь чичрэхээ больчихож. Өчүүхэн төдий тээнэгэлзэхийг Сталин гарцаагүй анзаарч, түүнд итгэхээ болино.

Ягодыг явмагц, Сталин Паукер Власик хоёрыг дуудуулав. Тэд үүдний өрөөнд хэзээний хүлээж байгаа билээ. Сталин хоёр цагийн дараа Курскийн галт тэрэгний буудлаас Сочи руу явна гэж тэдэнд мэдэгдэв.

Сталин хэзээ, аль буудлаас, хаашаа явахыг Паукер, Власик байтугай хэн ч, хэзээ ч эс мэднэ. Энэ тухай яг тулгаж байгаад л мэдэгдэнэ. Ийм зуршилтай учраас түүний галт тэрэг нь Москвад, усан онгоц нь Горькийд хоёр долоо хоногийн турш сойлттой мэт бэлэн байгаа ажээ.

Энэ удаа усан онгоцны хэрэг гарахгүй нь. Сталин заримдаа Горький, Сталинградыг дайрч Сочи руу явдаг ч энэ удаа Москвагаас тийшээ шууд очно гэж хэлжээ.

Улс төрийн Товчооны олонхи гишүүн амралттай байв. Харин Ежов Москвад үлдэж, “Зэрэгцээ төв”-ийн хэргийг шүүн таслах ажиллагааны бэлтгэлийг удирдан, Ягодын ажилд хөндлөнгөөс илт эрээ цээргүй оролцож байгаа ажээ.

Ежов ТХ-ны нарийн бичгийн даргын хувьд төдийгүй, Сталины тусгай даалгавраар Ягодын ажилд хошуу, хуруу дүрж байгаа нь илт. Ежов эрээ цээргүй, дээрэлхүү ааглуу буйн учир энэ. Ягода Сталины итгэлийг алдсан хэрэг.

Сталины итгэлийг алдана гэдэг ер нь юу гэсэн үг болох, дэндүү их юм мэддэг мань хүний хувьд тухайлан юу гэсэн үг болохыг Ягода ойлголгүй яахав. Итгэхээ больсон гэрчийг амьд үлдээдэггүй шүү дээ.

Энэ бүхэн тийм нь ч тийм. Гэхдээ түүний дэргэд байсных Генрих Ягода ч их юм сурсан. мань хүн Улс төрийн Товчоон доторхи хүчний харьцааг мэдэх тул өөрийн гэх горьдлого бий.

Улс төрийн Товчооны гишүүд наймдугаар сарын сүүл рүү амралтнаас уван цуван ирсээр Сталин, Жданов, Микоян гурваас бусад нь бүгд ирцгээжээ. Ягода ТХ-ны орлогч гишүүд гэдгийг нь харгалзан Бухарин Рыков хоёрыг шүүх асуудлыг Улс төрийн Товчоонд тэр даруй оруулав.

Ягодын тооцоо зөв болжээ. Рыков Бухарин хоёрыг зөвхөн Каганович, Ворошилов, Молотов гурав шүүхэд шилжүүлэх санал өгсөн байна.

Есдүгээр сарын 10-ны “Правда” сонинд Рыков, Бухарин нарын гэмт үйл ажиллагаа нотлогдоогүй учраас тэднийг мөрдөн байцаах ажил зогссон тухай мэдээ нийтлэгдэв.

Гэвч энэ нүүдэл Ягодаг аврах битгий хэл, уналтыг нь улам түргэсгэжээ.

1936 оны есдүгээр сарын 25-нд Сочигоос Сталин, Жданов нарын гарын гарын үсэгтэй цахилгаан Москвад, Улс төрийн Товчоонд ирлээ: “Нөхөр Ежовыг дотоод хэргийн ардын комиссараар томилохыг яаралтай бөгөөд зайлшгүй чухал гэж бид үзэж байна. Ягода троцкийчууд-зиновьевын эвслийг илчлэх чадваргүйгээ тодорхой харууллаа. Улс төрийн нэгдсэн газар энэ хэргийн тухайд дөрвөн жилээр хоцорч явна. Үүнийг намын бүх ажилтан, ДЯАК-ын ихэнх төлөөлөгчид анзаарсан байна”.

Сүүлийн таван үг Ягодаас бусад ДЯАК-ын удирдлага албан тушаалдаа үлдэх ёстой гэсэн утгатай юм байж.

Хэд хоногийн дараа Ежов дотоод хэргийн ардын комиссараар, Ягода холбооны ардын

комиссараар тус тус томилогдов. Энэ албан тушаалд байсан Рыковийг шинэ томилолт товлонгүйгээр чөлөөлжээ.

Ягодын орлогч Прокофьевийг усан тээврийн ардын комиссариатад шилжүүлж, Ежовын орлогчоор ГУЛАГ-ын дарга асан Матвей Берман, хилийн цэргийн командлагч асан Михаил Фриновский нарыг томилсноос өөр ДЯАК-ын удирдлагад ямар ч өөрчлөлт гарсангүй. Бүх ажилтан, Ягодын хувийн нарийн бичгийн дарга Буланов хүртэл байр байрандаа үлдэцгээжээ. Ежов ГХ-ноос хэдэн хүн дагуулж ирсэн нь үнэн, гэхдээ тэднийг Молчанов, Миронов, Слуцкий, Паукер зэрэг хуучин хэлтсийн дарга нарын туслахаар томилжээ.

Түүгээр ч барахгүй Сталин арван хоёрдугаар сарын 20-нд чекистийн байгууллагын ойд зориулсан бага шиг хүлээн авалтад ДЯАК-ын хуучин удирдлагуудыг урьж тэднийг итгэж буйгаа илэрхийлжээ.

Хүлээн авалт найрсаг, дотно, итгэмжилсэн уур амьсгалд болов. “Зэрэгцээ төв”-ийн хэргийг шүүх ажиллагааны бэлтгэлийн явцын талаар ярихыг Сталин хориглосон ажээ.

-Хөгжилдөн наргицгаа, анд нар аа гэж Сталин хэлэв.

Тийнхүү анд нар герман маягаар давсалсан гойд сайхан май загасаар даруулан архи ууцгааж хөгжилдлөө. Тэр загасыг тусгай хэлтсийн дарга, Сталины хувийн хамгаалалтын албаны дарга, түүний онцгой итгэмжит төдийгүй хувийнх нь үсчин, эцэж цуцахыг үл мэдэх Паукер олж ирдэг аж. Хоолойгоо бусдын тонгоргонд тавьж өгөхөөс илүү итгэл гэж хаа байх вэ?

Паукер нэгдүгээр дайнаас өмнө Будапештийн хошин дуурийн театрт үсчин байсан, хошин дуурийн алдартнууд өөрийг нь их авьяастай, тайзны урлагт орохыг зөвлөдөг байсан гэж сайрхдаг хүн.

Тэрээр үнэхээр алиа, хүн шоолохдоо нүгэлтэй, онигоо, ялангуяа еврейн болон завхай онигоо ярихдаа гаргууд. Төрөлхийн марзан Тэрээр дүнсгэр зожиг Сталиныг хүртэл хөгжөөж чадна.

Паукер энэ удаа буудуулахаар явж буй Зиновьевийг элэглэж үзүүлэв.

Хянагчийн дүрд тоглож буй Берман, Фриновский хоёрын мөрөн дээр Паукер үлхийн тэгнэчихээд нүд нь бүлтэгнэн эргэлдэж, гинаж гаслав. Өрөөний дунд хэрд Паукер өвдөг сөгдөн унаж, Фриновскийн гутлыг тэврэн наалдаад, “Нөхөр... Бурхны ач... Нөхөр... Иосиф Виссариановичид утасд л даа... Нөхөр...” гэж чарлав.

Бүгд инээлдэцгээв.

Сталин жуумалзах төдий болов.

Паукер Каменевийг элэглэж давтан тоглолоо. Өвдөг сөхрөн унасангүй, харин ч биеэ цэгцлэн, гэдсээ урагш түрж, гараа тааз руу сарвайгаад Каменевын сэхээтэн хоолойг дуурайн “Ээ, тэнгэр минь, намайг сонсох л доо!” хэмээн гоморхолтой өгүүлэв.

Дахиад л цөмөөрөө хөхрөлдөв. Харин Миронов, Молчанов хоёр инээхгүй буйг Сталин

анзаарчээ. Таалагдахгүй байх нь. Бас үүнийгээ нууж чадахгүй байна. Яллагдагсадын амийг хэлтрүүлнэ гэхийг түүний өрөөнд тэр нэг удаа сонсохдоо баярласнаа бас нууж чадахгүй байсан шүү дээ. Харуусч байх нь. Ээ дээ, энэ оросын гэнэн цагаан харуусал уу... Орос хүнд засгийн дээд эрхийг өглөө гэхэд өрөвдөж харуусч байгаад л нөгөө эрхээ тэр дорхноо алдчихна.

Харин энэ шүлхий салбадай оргисон Паукер давсыг нь ихдүүлчихлээ. Улс төр гэдэг чинь цирк биш, эмгэнэлт явдлыг наргиан болгож таарахгүй. Барлаг байх газраа мэддэг байх ёстой. Энэ адгуусны жинхэнэ байх газар нь дүүжлүүрийн шон. Аяс нь таарвал энэ этгээд ӨӨРИЙГ нь ч элэглэнэ. Муу панзны турсага!

Сталин хундагаа өргөн Миронов, Молчанов хоёр руу хандав:

-Нөхөр Миронов таны эрүүл мэндийн төлөө, нөхөр Молчанов таны эрүүл мэндийн төлөө. Нөхөр Миронов, Молчанов нарын эрүүл мэндийн төлөө, энэ нөхдөөр төлөөлүүлэн тавьсан үүрэг зорилтыг нарийн ойлгож, нарийн биелүүлдэг жинхэнэ чекистүүдийн төлөө тогтооцгооё.

Тэрээр хундагаа буулгалгүй, ширээ тойрон суугсадыг эргүүлдэн харав. Харин одоо хэр тасалгааны голд зогссоор буй Паукер, Берман, Фриновский гурав руу эргэж харсангүй.

Энэ болон дараа дараачийн шүүн таслах ажиллагааг бэлтгэсэн ДЯАК-ын бараг бүх ажилтныг устгажээ.

ЗСБНХУ-ын Дотоод хэргийн ардын комиссар Ягодаг 1938 оны гуравдугаар сард буудан алжээ.

Ардын комиссарын нэгдүгээр орлогч Аграновыг 1937 онд, орлогч Прокофьевыг 1937 онд, Берман, Фриновский нарыг 1939 онд, ЗСБНХУ-ын ДЯАК-ын Улсыг аюулаас хамгаалах ерөнхий газрын хэлтсийн дарга Молчанов, Миронов, Паукер, Шанин, Гай нарыг 1937 онд тус тус буудан алжээ. Слуцкий 1938 онд амиа хорлосон. Чертокийг баривчлахаар ирэхэд Тэрээр өрөөнийхөө цонхоор үсэрч үхсэн.

Мөн тэр үед олон тооны мөрдөн байцаагч дарга нарынхаа хамт устгуулжээ.

1937-1939 онд нийтдээ 20 мянга орчим чекистийг буудан алсан буюу урт хугацаагаар хүнд хүчир ажил хийлгэх ял оноожээ.

Саша хоёр жилийн өмнө энд ирээд анхныхаа шууданг тэсч ядан хүлээж байсан шигээ энэ жилийн өвлийн шууданг тэсгэлгүй хүлээлээ.

Түүний хамгийн сүүлд уншсан сонины дугаар нь Зиновьев, Каменев хоёрын хэрэгт оноосон ялын төлөвлөгөө бүхий “Правда”. Анх түүнийг уншаад нүд нь орой дээрээ гарч, ийм аймшигт ял тулгасанд итгэж ядан байж билээ.

Саша одоо шүүн таслах ажиллагааны бүх протокол, тэмдэглэл бүхий наймдугаар сарын хорьдын болон ес, аравдугаар сарын сониноо авчээ.

Шүүгдэгсэд Кировыг алсан, Сталин болон нам, төрийн хамгийн нэртэй бусад удирдагчийг алахаар завдаж байсан, Троцкийн шууд заавраар ажиллаж байсан энэ тэр гэж хүлээжээ. Шүүх ажиллагаа нээлттэй болсон ч өмгөөлөгч байхгүй, хэдхэн хоногт маш түргэн явагджээ. Яллагдагсад өдүүлсэн аймшигт хэргээ уриалгахан мэдүүлцгээж, тэр мэдүүлэгнүүд нь хоорондоо нэг хэвээр цутгасан мэт адилхан байхыг яана.

Энэ бүхэн Сашагийн ой тойнд олигтой бууж өгөхгүй байв. Ахмад коммунистууд, большевикууд, Лениний журмын нөхөд, Октябрийн баатрууд, иргэний дайны домогт жанжнууд, бүх насаа намд зориулсан хүмүүс алуурчин, хорлон сүйтгэгч, тагнуул болчихож. Лениний Улс төрийн Товчооны гишүүд, Октябрийн хувьсгалыг бэлтгэн ялуулсан хүмүүс ажилчдын хоол руу шилний хагархай хаялж, машин техникийг эвдлэж, гадаадын тагнуулын газрын хөлсний этгээд болцгоочихож. Энэ бүхнийг үнэн гэж үзэх юм бол намд итгэхээ болих хэрэгтэй. Эрүүгийн хэрэгтнүүдээр хэдэн арван жил удирдуулсан намын үнэ цэнэ гэж юухан байх билээ?

Тэд өөрснөө бүх хэргээ хүлээв үү? Саша үүнд даанч үнэмшсэнгүй. Нэг нэгнийхээ амыг дагуулсан, нэг маягийн мэдүүлэг чин сэтгэлийн мэдүүлэг байж таарахгүй. Тэд нар хэргээ хүлээсэн бус тэдний өмнөөс хэн нэгэн үүнийг хийсэн гэлтэй. хэн нэгэн тэдний дүрд тогложээ. Жүжигчид сонгож олоод, Зиновьев, Каменев, Смирнов, Мрачковский энэ тэртэй төсрүүлэн будаж шунхдаад тайзан дээр албадан гаргаж. Хаант засгийн шоронд төрсөн, иргэний дайны баатар Мрачковский Япон, Германы тагнуул, алуурчин, хорлоочин болчихоод энэ тухайгаа өөрөө ид бах болгон ярьж байх уу? Үгүй ээ, уучлаарай, Саша үүнд итгэхгүй! Жүжигчид! Эсвэл ховсдолт! Ямар нэгэн онцгой эм тариа! Магадгүй, тэднийг эрүүдэн шүүсэн юм болов уу? Үгүй ээ, энэ хүмүүст ямар ч эрүү шүүлт тулгаад тагнуул, алуурчин болгож чадахгүй. Энэ бол Звягурогийн ярьж байсан жүжиг.

Гэтэл үүнийг жүжиг гэдгийг Сталин мэдэхгүй байх ёсгүй. Сталины оролцоогүйгээр ийм жүжиг тавьж зүрхлэхгүй. Лидия Григорьевна Звягуро Сталин намыг хүйс тэмтэрч байна гэж хэлж байсан нь үнэн болж таарлаа. Энэ шившигтэй шүүх хурал, энэ хууль бус жүжиглэл Сашагийн аливаа эргэлзээг арилгав.

Сталин нэгийг хэлж, нөгөөг хийж байна, аман дээрээ ард түмний төлөө гэх боловч ачир дээрээ ард түмнээ айлган сүрдүүлж байна, айдас, хүчирхийлэл хоёр түүний засгийн гол зэвсэг. Тиймээс мань Саша хүчирхийллийг зогсоож чаддаггүй юм гэхэд айдаст автахгүй байж

чадах ёстой. Гагцхүү тэгж чадваас хүн хэвээрээ үлдэнэ.

Гэхдээ ховсдолт хүн болгонд жигд үйлчлээгүй бололтой. Иван Никитич Смирновын шүүх хурал дээр өгсөн мэдүүлэг үүнийг гэрчилнэ.

Алан хядлага явуулах тухай Троцкийн удирдамжийг Смирнов Москвагийн төв байгууллагад дамжуулсан гэж Мрачковскийн мэдүүлснийг Иван Никитич шүүх хурлын бүр анхны өдөр эрс няцаажээ.

Шүүн таслах ажиллагааны хоёрдах өдөр буюу наймдугаар сарын 20-нд “Смирнов бараг гурван цаг үргэлжилсэн байцаалтын явцад ЗСБНХУ-ын прокурор нөхөр Вышинскийн шууд тавьсан асуултаас элдвээр булзахыг хичээж, өөрийгөө жижигрүүлэхийг оролдон, нам, засгийн удирдагчдын эсрэг алан хядах үйл ажиллагаа явуулж байснаа үгүйсгэж байв” гэсэн мэдээ олон сонинд гарчээ.

Сонинд мэдээлснээр наймдугаар сарын 22-нд Смирнов “троцкийч-зиновьевч төвд зүтгэсэн хариуцлагаасаа мултрахыг дахин оролджээ.

Вышинский. Та төвөөс хэзээ гарсан бэ?

Смирнов. Надад гарах бодол огт байгаагүй, юунаасаа гарах вэ дээ.

Вышинский. Төв байсан уу?

Смирнов. Юуны чинь төв...

Вышинский. Мрачковский, төв байсан уу?

Мрачковский. Байсан.

Вышинский. Зиновьев, төв байсан уу?

Зиновьев. Байсан.

Вышинский. Евдокимов, төв байсан уу?

Евдокимов. Байсан.

Вышинский. Бакаев, төв байсан уу?

Бакаев. Байсан.

Вышинский. Смирнов, та төв байгаагүй гэж яаж зүтгэж чадаж байна аа?

Хуралддаггүй төв гэж байхгүй, хуралдаан болж байгаагүй байна гэдэг нэрийдлээр Смирнов дахиад бултахыг оролдсон боловч Зиновьев, Тер-Ваганян Мрачковский нар түүний худлаа мэдүүлж байгааг зад илчлэв”.

Смирнов цор ганцаараа эцсээ хүртэл эрэлхэг зоригтой байжээ. Сонинд мэдээлснээр, тэр наймдугаар сарын 23-нд эцсийн үгээ хэлэхдээ, “Баригдсанаас хойшхи хугацааны троцкийч-зиновьевч алан хядах төвийн үйлдсэн ялт хэргийн хариуцлагыг хүлээхгүй гэдгээ дахин мэдэгджээ”.

Тэгэхээр нугараагүй хүн үлдсэн байх нь. Тэгэхээр энэ бол жүжиг биш. Тэгвэл энэ чинь юу юм бэ? Бусдыг нь юугаар, яаж нугалав?

Саша олон нийтийн санаа бодлыг үзээд юунаас ч илүү гайхжээ. Үйлдвэр завод, элдэв сургууль хүрээлэн, ардын комиссариатын хамт олныг яая гэхэв. Бөөн байж байгаад цөмөөрөө гар өргөчихдөг юм чинь. Шүүх хурлаас гурав хоногийн өмнө, наймдугаар сарын 16 гэхэд сонин хэвлэлээр ажилчдын цуглааны тогтоолууд эрээлжилж эхлэжээ.

“Ардын дайсанд ямар ч өршөөл байх ёсгүй!”

“Хорт могойнуудыг устга!”

“Заналт дайснуудыг үтэр тонилго!” Энэ мэтийн шаардлагатай тогтоолууд.

Гэтэл алдартай зохиолчид, жүжигчид, эрдэмтдийн саналыг юу гэж үзэх вэ! Ёстой аймшигтай юм тэр.

Бүр наймдугаар сарын 15-нд, шүүх хурлаас дөрөв хоногийн өмнө буюу хуйвалдаан илрүүлсэн тухай ЗСБНХУ-ын Прокурорын газрын мэдээлэл нийтлэгдсэн өдөр нэрт зохиолч Ставский: “Увайгүй балмадууд, та нарын нэр үеийн үед хараал идвэл таарна!” гэж бичсэн байв.

Наймдугаар сарын 20-нд зөвлөлтийн зохиолчид ийнхүү тунхаглажээ:

Анна Караваева: “... троцкийч-зиновьевч эвслийн хорт харгисуу-дыг жигшин зэвүүцсэн сая сая хүний сэтгэл зүрх бухимдан булгилж, нудрага нь зангиран чангарч байна”.

Иван Катаев: “Ард түмний уур хилэн алуурчид, галдагчдын үүр уурхайг үнсэн товрог болгог!”

Владимир Бахметьев: “Амьсгалаа хурааж буй империализмын саравчинд чарлаж байгаа хорт могойнуудыг үл хөрөх хилэнт зэвүүцлээр үеэс үед жигших болно”.

Николай Огнев: “Дээд шүүхийн ял бол зөвлөлтийн бүх ард түмнээс оноох ял. Энэ ял хатуу бөгөөд шудрага байх болно”.

Наймдугаар сарын 21-нд:

Алексей Толстой: “Эдүгээ зөвлөлтийн шүүхээр төдийгүй олон улсын бүх пролетари нарын шүүж буй тэрсүү урвалт бол хүн төрөлхтний түүхэнд мэдэгдэж байгаа хамгийн шившигтэй муухай урвалт мөн”.

Наймдугаар сарын 25-нд:

“Зөвлөлтийн Зохиолчдын эвлэлийн тэргүүлэгчид фашизмын тагнуул, алан хядагчид, хорлон сүйтгэгч троцкийч-зиновьевчуудыг буудан алах тухай пролетарийн шүүхийн шийдвэрийг халуунаар талархаж байна”.

“Хэрэг явдал... Зөвлөлтийн Зохиолчдын эвлэлийн бүрэлдэхүүнийг үндсээр нь шалгаж үзэх шаардлагатайг харуулж байна. хэнтэй харьцаж байгаагаа м э д э х хэрэгтэй байна. Манай ЗЗХ-ны 3000 гишүүнийг бүгдийг нь мэдэх хэрэгтэй...”

Вс.Вишневский.

“Энэ Каменевууд, Зиновьевууд чинь хэн байв аа?

Эд нар бол хүн биш!

Эд нар бол хүн дүрст нөхөд байж!”

А.Гидаш.

“...Тэднийг буудан алсан, үүнээс хойш тэднүүс газар дээр байхгүй гэж бодохоос бид бүхний сэтгэлээс бөөн хар юм авч хаясан мэт боллоо...”

Тэд нар манай сайхан орны агаарыг дахин хордуулж бузарлахгүй!”

А.Барто.

Саша эдгээр шаардлагыг унших тусам учраа олохоо бүр болих янзтай. Эд нар чинь зохиолчид шүү дээ! Зохиолчид! Ард түмний сэтгэлийн толь! Пушкин, Толстой, Достоевский, Чехов... гээд Орос газарт зохиолчдыг хэзээнээс нааш ард түмний сэтгэлийн толь гэж үздэгсэн.

Тэгэхээр зохиолчид итгэж байх нь. Тэгэхээр энэ үнэн гэдгийг мэдэж байх нь, яллагдагсад үнэхээр алуурчид, тагнуулууд гэдгийг мэдэж байх нь...

Ачир дээрээ үнэхээр тийм юм бол уу?!

Харахгүй юу, сөрөг хүчинд үзэл бодлоор нэгдэж явсан нөхөд нь хүртэл сонины хуудсаар тэднийг хараан зүхэж байна шүү дээ.

Х.Раковский: “Нөхөр Кировыг алагчид, манай хайрт жолоодогч нөхөр Сталин, нам, засгийн бусад жолоодогчийн амь насанд халдах явуулгыг зохион байгуулагчид, германы гестапогийн тагнуул- троцкийчууд, зиновьевчуудад ямар ч өршөөл байх ёсгүй, тэднийг буудан алах хэрэгтэй”.

Г.Пятаков: “Манай цэцэглэн хөгжиж байгаа сайхан орны

амьсгалж байгаа цэвэр цэнгэг агаараас гэнэтхэн улс төрийн үхдлийн ой гутам үнэр ханхийлээ. Аль хэзээний улс төрийн хүүр болсон хүмүүс өмхийрч ялзрахдаа орчин тойрныхоо агаарыг хордуулж байна. Эд нар бол хүмүүн төрхнийхөө эцсийн шинжийг гээсэн

хүмүүс. Тэднийг Зөвлөлт орны цэнгэг ариун агаарыг бузарлаж буй сэг лүгээ адил устгах хэрэгтэй. Манай жолоодогчдын амь насыг бүрэлгэж чадах аюултай сэг лүгээ адил устгах хэрэгтэй. Манай орны хамгийн сайн хүний нэг, гайхамшигт нөхөр, удирдагч С.М.Кировын амь насыг нэгэнт хөнөөсөн сэг лүгээ адил устгах хэрэгтэй”.

Карл Радек: “Шүүх хурлын танхимаас... хүүрийн үнэр даян дэлхийд ханхалж байна.

Пролетарийн хайрт удирдагчдын эсрэг зэвсэг агсаж, хэмжээлш-гүй нүгэл хийсэн хүмүүс толгойгоороо төлбөр хийх ёстой”.

Гэтэл Пятаков, Раковский, Радек гурав чинь тун саяхан болтол гол троцкийчууд, Троцкийн гол туслахууд, түүний үнэнч анд, түүнийг дагаж явсан хүмүүс шүү дээ. Тэд нар худлаа гэрчлэх ёсгүй... Тэгвэл энэ бүхэн үнэн болох нь уу? Тэгвэл Зиновьев, Каменев, Смирнов, Мрачковский нар алуурчин, тагнуул гэсэн үг үү?

Тэгвэл эрдэмтэд юу гэж байна?

“Зөвлөлт орны агаат дайснуудыг хайр найргүй устга!” гэж академич Бах, Келлер хоёр шаардсан байна.

Лурия, Вышневикий, Шерешевский, Готлиб, Маргулис, Гори-невская, Вовси зэрэг олон профессор: “Нам, Сталин хоёртоо бид хязгааргүй хайртай. хүн төрөлхтний эрхэм нандин хүсэл тэмүүл-лийн биелэл болсон аугаа их жолоодогчоо бид амьд цайз болон хүрээлж, эцсийн дусал цусаа дуустал хамгаална.

Улс төрийн дампуурсан зандалчдад ямар ч өршөөл уучлал байх ёсгүй” гэж бичигцгээсэн байна.

Тэгвэл соёлын зүтгэлтнүүд?

Найруулагч Птушко: “Бид большевикч сонор сэрэмжээ дээшлүүлж, троцкийчууд-зиновьевчуудын эх орноосоо урвагчдын өнгөлзлөгөөс хувьсгалт ололтоо нүд цавчихгүй хамгаалах ёстой”.

Ардын жүжигчин Ак. Васазе: “Фашистын зандалчдыг буудан алахыг би шаардаж байна. Манай аугаа эх орноос урвагчид, дайснуудыг хэрхэвч өршөөж болохгүй”.

Ардын жүжигчин М. Климов: “Гурав хоногийн өмнө “Известия” сонинд Кадийн нэгдүгээр сургуулийн 10 дугаар ангийн сурагч Ева Нерубинагийн шүлэг нийтлэгджээ. Тэр шүлгийн дахилтад троц-кийч-зиновьевч алан хядагчдын хаягаар: “Ганц ялаа эдлэж, ноход мэт буудуул!” гэж өгүүлсэн байна.

Өндөр настан, ардын жүжигчин би вээр охины амнаас гарсан энэ үгстэй санал бүрэн дүүрэн нийлж байна”.

Ева Нерубинагийн бүх сонины хуудас дамжсан нөгөө шүлэг нь энэ:

Хэдэнтээ хараал идсэн зэвүүн могойнууд

хэний амь насанд халдана гэнэ ээ.

Гайгүй ээ! Та нарыг дахиад өршөөхгүй.

Ганц таарах ялаа эдлэж, нохой мэт буудуул!

Хүүхдийн энэ шүлгийг уншаад Саша дотор нь харанхуйлах шиг болжээ. хүнийг н о х о й мэт буудан алахыг хүүхэд шаардаж байна. Тэгж яривал нохойг яагаад буудаж алж байх ёстой билээ? Хүүхдүүд чинь адгуусан амьтныг хайрладаг шүү дээ. Эсвэл бүр хайрлахаа больчихсон юм уу?

Ингэхэд ер нь юу гээч болоод байна аа? Юу вэ? Нөгөө үнэн маань хаана байна?

Саша уул нь бүх шуудан, бүх сонингоо бушуухан гүйлгэж харчихаад, дараа нь нэгбүрчлэн тогтож уншдаг билээ.

Тэрээр энэ удаа эхнээсээ л наймдугаар сарын сониноос салж чадахгүй болчихов. Шүүн таслах ажиллагааны тухай тайлан, түүнд өгсөн үнэлэлт дүгнэлтийг үг бүрчлэн тунгааж, хэд дахин уншив. Энэ бүхэн өөрийнх нь хувь заяатай холбоотойг ойлголгүй яахав. Цөвүүн цаг ирж байна, тэр цаг нэг том жүжгээр эхлэж байх нь. Ингэж бодохуйд Всеволод Сергеевич, Лидия Григорьевна хоёрын хэлсэн зүйл орой руу нь орох ч шиг.

Саша дөнгөж маргааш нь бусад сонин руугаа оров.

Зургадугаар сард генерал Франкогийн бослогоор Испанид иргэний дайн эхэлсэн аж. Бүгд найрамдах засгийн эсрэг марокко, герман, италийн байнгын армийн ангиуд байлдаж байгаа гэнэ. Мадрид, Барселона, Валенси, Баскони, Андалузи, Эстрададура, Астури, Кастили, Ирун гэхчилэн испанийн хот, мужийн нэрс, бас Асанья, Хираль, Ларго Кабальеро, Хосе Диас, Долорес Ибаррури гэх мэт шинэ хүмүүсийн нэрс сонины хуудаснаа элбэгшжээ.

Зиновьев, Каменев нарыг цаазласны дараа сонин хэвлэлийн хийрхэл дорхноо зогсчээ. Есдүгээр сарын 10-нд ЗСБНХУ-ын Проку-рорын газрын мэдээлэл нийтлэгдэв: “Н.И.Бухарин, А.Н.Рыков нарыг шүүхийн хариуцлагад татах эрх зүйн өгөгдөхүүн мөрдөн байцаалтаар тогтоогдоогүй учраас уг хэргийн ажиллагааг зогсоов”. Дотоод хэргийн ардын комиссар Ягода албан тушаалаасаа ава-хуулж, Ежов гэгчээр солигджээ. Сталин ухралт хийхэд хүрсэн байна, нам Сталинаас хүчтэй болж таарсан хэрэг, намын боловсон хүчин Сталиныг сөрөх, түүний залхаан цээрлүүлэх бодлогыг хазаарлан саад тавих чадвартай байсан хэрэг. Сталин баашилж байгаа байж магадгүй, баашлана гэдэг чинь тэгтлээ дураараа загнаж чадахгүй байна гэсэн үг, тэгэхээр нам сонор сэрэмжтэй байна гэсэн үг.

Гэхдээ Сашагийн мэл гайхаж, цэл хөхөрсөн юм бол шинэ Үндсэн хуулийн төсөл. Бараг итгэхийн арга алга. Бүх нийтийн тэгш, шууд, нууц сонгох эрхийг тогтоож, ЗСБНХУ-ын иргэдийн хүйс, яс үндэс, хөрөнгө чинээг үл харгалзан тэгш эрх, бүрэн ардчилсан эрх, эрх чөлөөг баталгаажуулж, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх, хурал, цуглаан,

жагсаал хийх, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөөр хангаж баталгаажуулжээ.

Энэ бүхэн бол эрх чөлөө, ардчилал, хуульт ёсны зүг эргэлт хийж байгаа хэрэг. Мэдээж, “Сталины үндсэн хууль” гэдэг нэр олигтой зохихгүй байна. Гэхдээ нэрэндээ биш нидэртээ шүү дээ! хэн ч байсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, тэр ч бүү хэл, хэвлэн нийтлүүлж, чөлөөтэй цугларч, жагсаал зохиож болох нь. Наймдугаар сарынх шиг шүүн таслах ажиллагаа явуулах боломж хасагдлаа, тийм ажиллагаа хэзээ ч давтагдахгүй. Хууль бус явдал эцэс боллоо! Сталин бүр “Хуулийн тогтвортой байдал одоо бидэнд хэзээ хэзээнээс илүү хэрэгтэй болж байна...” гэж хэлсэн байна.

Зөвлөлт Холбоот Улс ийм Үндсэн хууль батлаж чадаж байгаа юм бол аргагүй хүчирхэг болжээ! Зөвлөлт засгийн газар ямар нэг гэрээгээр Испанийн дотоод хэрэгт оролцохгүй байх үүрэг хүлээгээгүй гэж мэдэгдсэн. Энэ бол бид Бүгд найрамдах Испанид туслана, интернационалч үүргээ биелүүлнэ, фашизмд цохилт өгнө гэсэн үг. Бүгд найрамдах засгийг хамгаалахаар Испани руу сайн дурынхан явж байгаа мэдээ цухалзаж байна. Хэрвээ Саша суллагдвал, одоо бол мань хүнийг суллахгүй байх ёсон байхгүй, тэр даруй сайн дурынханд элсэнэ, түүнийг Испани руу явуулаг. Тэнд коммунистууд фашистуудтай тулалдаж байгаа, тэнд коммунист Тавдугаар хороо Мадридыг хамгаалж чадсан.

Эрх чөлөөтэй болох найдвар дахин туяарлаа. Сашаг одоо хууль, Үндсэн хууль, шинэ хувьсгалт өрнөлт ивээн хамгаалж байна. түүнд ялын шинэ хугацаа нэмж зүрхлэх хүн байхгүй, түүнийг заавал суллах ёстой. Нэгдүгээр сарын 19-нд Алферов дээр очиж суллахыг шаардана. Үгүйдээн ганц өдөр саатуулсан ч хуулийг бүдүүлгээр зөрчсөн хэрэг болно, мань хүн Калининд цахилгаан явуулаад л буруутай этгээдийг хатуу шийтгүүлнэ. Хууль бол хууль, хэн боловч хуулийг сахих үүрэгтэй, тийм учраас цөллөгийн хугацаа дууссан хүнийг ганцхан хоног ч илүү барих эрхтэн хаа ч байхгүй.

Хүлээсэн өдөр нь удахгүй ирнэ гэхээс Саша самгардах төдийгүй уймрах шиг болов. Суллаж тавилаа гэхэд, суллах нь зайлшгүй шүү дээ, замд хүрэлцэх мөнгөтэйсэн бил үү? Тайшет хүртэл унааны хөлс өгөх ёстой, түүнээс цааш яах вэ? Москва хүрэх тасалбар 50 рублиэс лав наашгүй, бас голоо зогоож явах хэрэгтэй болно. Мөнгө нь хүрэх л ёстой доо. мань хүн хэдий хориглосон ч, ээж нь сар болгон 20 рубль явуулсаар байгаа. Өөрөө хөдөлмөр өдрийнхөө тооцоогоор суугаа айлдаа үнэгүй хооллож байгаа. Тамхи, керосин хоёроос өөр

юманд мөнгө үрэхгүй байгаа. Одоо улам гамтай зарна аа.

Тэрээр урьдын адил махран ажилласаар дахиад дөрвөн өгүүллэг бичжээ. Түрүүчийнх шиг бүгдийг нь хуулж бичээд нэг хувийг ээждээ явуулсан. Хэрэг болохын цагт ээжид нь бүгд хадгалаастай байх ёстой.

Тэг тэгсээр 1937 оны нэгдүгээр сарын 19-ний өдөр ирлээ.

Урд өдөр нь Саша юмаа эмхэлж жин тан болгожээ. Юу ч тохиож мэднэ: Шууд баривчлаад авч ч мэднэ, нэн даруй Красноярск яв гэж тушааж ч мэднэ. Үндсэн хууль үндсэн хуулиараа, аливаа хууль бол хууль, гэтэл ДЯАК өөрийн гэсэн хуультай.

Энэ шөнө Сашагийн нойр хүрэхгүй их удаж.

Алферовтой ярилцах юм хэдий тодорхой ч мань хүн яаж ярихаа дахин дахин бодож. Ямар бэрхшээл үүсч болохыг тунгааж. Ямар санаандгүй юм болж мэдэхийг эрэгцүүлж.

Эрх чөлөөтэй болох тэр мөчийг гурван жил хүлээсэн, одоо түүнтэйгээ золгох уу, үгүй юү? Алферов Кежмадаа байхгүй, нөгөө Красноярск руугаа явчихсан байвал яана? Тийшээ нэг явахаараа хэдэн долоо хонодог гэсэн. Районоор бас сар хэртэй явна, районы томыг ч хэлэх үү, унаа гэвэл өвлийн цагт чарга, зуны цагт завь. Алферов эзгүй байвал өөр ярих хүн ч олдохгүй, түүний эргэж ирэхийг хүлээж дахиад шаналж зовох хэрэг болно. Иймэрхүү урамгүй бодол толгойд нь эргэлдэнэ.

Саша долоон цагт, нар битүүгээр гэрээсээ гарав.

Арван хоёр километр, гурван цаг яваад арав гэхэд Алферов дээр оччихно.

Ойрын хэд хоног цас ороогүй болохоор чарганы зам дагтаршин нягтарчээ. Гагцхүү гачуурын саравгар мөчир дээр цас өдөн дэр шиг пөмбийжээ. Нутгийнхан кухта гэх. Жавар гуч орчим хэм байгаа болов уу. Агаар хүртэл царцчихсан мэт санагдана. Гэхдээ алтан жигүүр модноос мод руу нисч, нэлээн алсад болов уу, хаа нэгтээ тоншуул мод балбаж, моддын оройгоор улаан элэгт зана гангарч, самарч шаазгай мөчир дотор бултганана. Энэхэн анир чимээ л ойн нам гүмийг улам тодотгож байх шиг.

Тооцоолсон ёсоор Саша арван цагт Кежмад ирж Алферовын байр руу очив. Гал тогооны цантсан цонхонд зуухных юм уу, дэнлүүнийх юм уу гэрэл гологноно... Үүдний довжооны хажуугаар өчигдөрхөн явсан мөр байна, эднийх ашгүй, хүнтэй байх нь. Саша явган хаалга руу цагираган бариулаар нь тогшилсон боловч хариу ямар ч чимээ алга, нохой ч хуцсангүй. Алферов унтаж байгаа байх. Гэтэл хүлээх арга алга, пальто нэвт жиндэн, эсгий гуталтай ч хөлийн хуруу бээрчихсэн бололтой, ингээд зогсоод байвал осточихно. Саша гэрэл гологнож байгаа цонх руу очиж тогшив. Дахиад нэг тогшив. Гал тогооны өрөөгөөр нэг юм сүүтэгнэн цонх руу хүн ирэх шиг болов. Тэгснээ сүүдэр цонхноос холдож хэсэг зуур чимээгүй болсныг бодвол гэрийн эзэгтэй дулаан хувцсаа өмсөө биз. Үүдний пингийн хаалга хяхтнан, цасан дээр хөлийн чимээ хяхарч, явган хаалганы оньс торхийн мултрав. Сашагийн өмнө эсгий гуталтай, үстэй дээлтэй, алчуураа ороосон эзэгтэй тодров.

-Та хэнтэй уулзах гэв?

-Нөхөр Алферовтой.

-Арай эрт ирж дээ, тэднүүс унтаж байгаа.

-Би Мозговоос ирлээ.

-Тэгвэл ороод хүлээзнэ.

Саша эзэгтэйн араас пинд орж, түүнийг дуурайн эсгий гутлаа тайлаад, авгайн зааж өгсөн

үйсэн шаахайг углаж гал зуух руу оров.

-Тайчаад ийшээ суу, энд дулаахан байгаа гэж эзэгтэй өгүүлэв.

Саша пальтогоо тайлж өлгөөд, орчноо эргүүлдэн харав. Эзэгтэй дэвтээсэн жимсгэнэ, загастай бялуу таваглаж, шилэн аяганд цай хийж өглөө.

-Юм идэж, цай ууж бүлээц.

-Баярлалаа.

Саша аягатай цайг гардан авч бээрсэн хуруугаа бүлээцүүлэв.

-Холоос яваа юм байна, зам хунгарлачихаагүй байна уу?

-Зам сайхан байна.

Саша цайнаас нэг оочив.

Байшин дотор хаалга дуугарч, тамхичин эрэгтэйн ханиалгах сонсдов.

-Виктор Герасимович босцгоож байна, тэд нар өөрснөө угаа-гууртай, тэндээ сахал самбайгаа хусч, тэндээ нүүр гараа угаацгаадаг юм, бас хаалга үүд ч бий гэж эзэгтэй Сашаг тайвшруулах маягтай тайлбарлав.

Дахиад хаалга дуугарав. Алферов гаднаас орж ирээд гутлынхаа цасыг гүвэв бололтой. Дараа нь угаагуурын түлхдэг төмөр дуугарч түмпэнд ус савирах сонсдов.

Эзэгтэйд нь энэ чимээ дохио болов бололтой, халуун тогоо, Сашаг дайлсан жимс, бялуу энэ тэрээ хоолны өрөө рүү оруулаад, буцаж ирэнгүүт хайруулын тавгаа тулган дээр тавьж өндөг шарлаа.

Алферов хоолны өрөөнд орж, сандал татаж суугаад, цай аягалж байгаа нь мэдэгдэв. Эзэгтэй шарсан өндгөө аваад тийшээ орлоо.

-Өглөөний амгаланг айлтгая, Виктор Герасимович, сайхан нойрсов уу, элдвийн юм садаа болоогүй биз дээ?

-Баярлалаа, сайхан унтлаа гэж Алферов хариулав.

-Энд таныг хүлээж байгаа шүү, Виктор Герасимович.

-хэн хүлээж байгаа гэж?

-Нэг эрэгтэй хүн хүлээж байна, Виктор Герасимович.

-Тэр чинь хаа байна?

-Гал тогоонд сууж байгаа, гадаа сүрхий жаварлаж байна, дулаа-цаг гээд оруулчихсан, Мозговоос яваа юм байх.

Сандал түрхийв. Хаалгаар Алферов цухуйж Саша руу ширтлээ.

-Та юу? Яах гэж ирээв?

Саша бослоо.

-Өчигдөр миний хугацаа дууссан...

Алферов үгийг нь тасдан,

-Өө, тийм үү? Наашаа ороод ир гэв.

Саша Алферовын араас зочны өрөө рүү орж, ширээний цаад талд зааж өгсөн сандал дээр Алферовын өөдөөс харж суулаа.

-Та цай уух уу? гэж Алферов асуув.

Саяхан боссоных юм уу, өчигдөр жаахан юм балгасных юм уу, түүний царай яльгүй сэлхэрчээ. Саша түүнийг сүүлчийн удаа харс-наас хойш нэлээд байр сууж бойргошсон гэлтэй. Өмднийхөө түрийг эсгий гутал руу дарж, цамцныхаа гадуур нэхий хантааз өмсчээ.

-Баярлалаа, танай эзэгтэй намайг дайлж цайлсан.

-Сайхан зантай авгай шүү. Намайг алах гээд нэг хүн ирлээ гэж санахад мань авгай түүнийг эхлээд цадтал ханатал нь идэж уулгана. Та явган ирэв үү?

-Явган.

Алферов шарсан өндгөө идэж эхлэв.

-Аа тийм үү. Намайг бага байхад асрагч маань “өнчин хүүхдийг хооллож, ундаалж, дулаацуулж гэнэ” гээд л шүлэг унших. Би тэр өнчнийг өрөвдөөд уйлчихдаг сан. Тэгээд дараа нь мартчихсан, тэр үеэс хойш нэг ч удаа санаанд орж байгаагүй. Тэгсэн чинь сая санаанд ороод ирлээ.

-Намайг хараад тэр үү?

-Магадгүй.

-Тэгвэл өрөвдсөн байх нь ээ гээд Саша жумалзав.

-Байж болох зүйл. Би сая, уучлаарай, хүндэрсэн чинь золтой л бөгсөө хөлдөөчихсөнгүй, уул нь манай жорлон саравчин дотор учраас салхи энэ тэр байхгүй л дээ, гэтэл та арван хоёр мод газар таваргаж ирж. Тэгээд л таныг өрөвдөж байгаагаа шүлгээр илэр- хийлэхгүй юу. Та чинь

утга зохиолоос нэг их дөлдөггүй байх аа?

-Тийм шүү, унших дуртай. Унших юм байвал тэр шүү дээ.

-Энд ч унших юм нээрэн ховор шүү. Түрүүхэнтэйгээ таныг багш хүүхэн номоор хангаж байсан, одоо тэр байхгүй. Шинэ багштай яагаад танилцаж болохгүй гэж? Бас залуухан, аятайхан бүсгүй шүү дээ.

Зохисгүй асуулт учраас Саша царайгаа барайлган чимээгүй өнгөрөв.

-Таалдаггүй байх нь ээ дээ. Панкратов, та ийм л эрх дураараа байгаа хүн гээд Алферов инээд алдав. -Хоригдож байгаа хүнд, мянга мянган хоригдолд, бум буманд хоригдолд хүүхэн гэдэг чинь ерөөсөө санах юм биш. Хэрвээ хэн нэгэнд тийм аз тохиох юм бол юун голох шилэхтэй мантай. Эм л бол бол оо. Тэгэхэд та их цамаан загнаж байна, танд боловсролтой төдийгүй бусад үзүүлэлтээрээ бас дээд зэргийнхийг талбин олгож байх ёстой болох нь. Та ийм л эрх дураараа амьдарч байгаа хүн дээ.

Алферовын олон үг Сашад тээртэй санагдлаа. хүний амьдрал, хувь заяа шийдэгдэх гэж байхад чалчих цагаа мөн олов оо! Алферов, мэдээж, дэмий хоосон чалчихгүй, чалчихынх нь цаана заавал нэг юм байгаа. Тэр шинэ багш хүүхний тухайд зүгээр нэг дурсаагүй. Сашад шинэ хугацаа нэмээд тохчихсоныг мэдэж байгаа хэрэг, тэгээд л шууд хэлчихгүй, эгдүүг нь хөдөлгөж, зугаагаа гаргах санаатай байх нь.

Саша толгойгоо гудайв.

Гуниг, гуниг. Энэ Мозговын амьдрал, энэ аймшигт ганцаардлыг мань хүн цаашаа тэсч чадахгүй. Ер нь ийм амьдралаар яах юм бэ! Ээж нь? Ээж яах вэ дээ? Хүүхэд нялхаараа ч үхдэг юм чинь ээж нь тэсч л таарна.

-Ийм эрх дураараа амьдралтай хүн юу хийх вэ? Ялангуяа түүхийн шинжлэх ухаанд сонирхолтой хүн? Ялангуяа унших юм байхгүй бол...

Алферов ингэж асууснаа, Сашагийн хариуг хүлээлгүй,

-Өөрөө бичих хэрэгэй. А-аан? Тийм үү? гэв.

Ойлгомжтой. Ээждээ явуулсан өгүүллэгүүдийг нь уншчихаж. Энэ тухай ярихгүй байж болно доо, аргагүй л адгуус юм байна.

-Би бас бичдэг хүн, гэхдээ түүхээр биш гүн ухаанаар. Сайрхаж болох байна гээд Алферов ажлынхаа өрөө рүү орж, хэвлэмэл багц хуудас барьсаар эргэж ирэв. -Хар даа, миний шинэ номны боолт, энд, Кежмад бичсэн юм. “Декартын философийн үндэс”. Декартыг та уншаагүй юү? Үгүй ий? Сониуч гүн ухаантан, бодитой оршин буй ертөнцийг бурхантай холбох гэж оролдсон хүн. Та гүн ухаан сонирхдоггүй юм уу? Тоогүй хэрэг. Түүхч хүн гүн ухаантан байх ёстой, бас гүн ухаантан түүхч байх ёстой.

Алферов чимээгүй бодолхийлснээ жуумалзав.

-Таны санааг би таамаглаж байна: Энэ муу нохойн гөлөг Алферов миний бүтээлийг уншсан байх нь! Уран бүтээлийн дотоод сэтгэл рүү минь балиар савраа дүрсэн байх нь! Би үнэнээ хэлье. Тийм ээ, уншсан, тийм ээ, дүрсэн. Тийм албатай хүн. Харин санаа зовох хэрэггүй. Таны бүтээлүүд явуулсан газар руу чинь яваад өгсөн. Миний хувьд бол би таны анхны уншигч, анхны шүүмжлэгч. Миний бодлыг мэдмээр байна уу?

Эрүү шүүлт! Хувь заяаг нь хэлж өгөхийн оронд элдвийг бураад л. Гэвч биеэ барих хэрэгтэй! Өөрийнхөө төлөө тэмцэхдээ л нэг тэм-цэнэ! Одоо хуйсганах юм бол суллагдах эсэхдээ эргэлзэж байгаагаар Алферовт мэдэгдчихнэ, тийм байдал харуулж хэрхэвч болохгүй, өнөөдрөөс эхлээд эрх чөлөөт хүн болсон, ёстой ярихгүй! Хуц ваа, гай нь ирээгүй бол гайгүй байлгүй!

Саша нэг их дуртай биш ч,

-Сонсоё л доо гэж хариулав.

-Хэлбэр талаасаа бол таны бүтээл арчаагүй, гэнэн, тэр ч байту-гай эгэл болхи юм билээ. Баахан гоё чамин хэллэг, гуншин чимэг.

Алферов өөртөө цай аягалж, Сашад хийж өгөх гэтэл цаадах нь татгалзав.

-За, цаашилбал. Францын их хувьсгал бол хүн төрөлхтний түү-хийн хамгийн эгзэгтэй, сургамжтай, би энэ үгийг цохон хэлж байна шүү, сургамжтай мөчийн нэг. Гэтэл та тухайлсан хүн, тухайлсан хэрэг явдлын талаар бичиж байна. хэнд зориулаав? Хүүхдэд үү, залуучуудад уу, насанд хүрсэн уншигчдад уу? Ойлгомжгүй байгаа. Тэд уншсан зүйлээсээ ямар дүгнэлт хийх ёстой болж байна? түүнээс гадна гэснээ Алферов Саша руу сонжих мэт хараад, - редактор зэрэгцүүлэх адилтгал хайна гэж та айхгүй байна уу? гэж асуув.

-Ямар адилтгал? хэмээн Саша ойлгож ядан асуув.

-Ямар байж болохов? Тэднийд хувьсгал хийсэн, манайд хувьсгал хийсэн. Тэдний хувьсгал юугаар дууслаа? “Термидорын” (11 дүгээр сарын) эргэлтээр, Наполеоны ганцаар эзэрхийлэх засаглалаар, эзэнт улс тогтоосноор дууссан...

-Та болгоогоорой, тэр чинь хөрөнгөтний хувьсгал байсан, манайх бол пролетарийн хувьсгал.

-Тэр ч тийм шүү хэмээн Алферов яриаг таслав. -За яахав, та өөрөө мөрөөрөө байвал, таны бүтээлийг хэвлэчих ч юм бил үү, хоригдлуудын бүтээлийг манайх хэвлэдэггүйг та мэднэ. Тийм учраас хэдийгээр эргэлзэж байгаа ч гэсэн танд амжилт ерөөе.

Тэрээр дуугүй болж амаа арчаад, тамхиа асааснаа хайрцагтай тамхиа Саша руу өгөв.

-Би өөрийнхдөө дассан хүн.

-Өөрийнхийгөө тат тат, миний энд чинь гарын тамхи хүртэл татдаг юм.

Саша тамхиа асааж, Алферовын түүн рүү дөхүүлсэн үнсний саванд шүдэнзээ унтраагаад,

-Нөхөр Алферов, миний цөллөгний хугацаа өчигдөр дууссан гэж хэлэв.

-Тийм үү? Тэгсэн гэж үү? хэмээн Алферов гайхсан дүр эсгэн сөргүүлж асуулаа.

-Тийм, би танд түрүүн хэлсэн шүү дээ. Би урьдчилан хоригдсон

хугацааг оролцуулан гурван жилээр яллуулсан, 1934 оны нэгдүгээр сарын 19-нд анх баривчлагдсан, өнөөдөр 1937 оны нэгдүгээр сарын 19. Тийм учраас би өнөөдрөөс эхлэн эрх чөлөөтэй болсон. Надад бичиг баримт шийтгэж өгөхийг хүсч байна.

-Та ямар бичиг баримтыг хэлж байна?

-Ийм тохиолдолд олгодог бичиг баримтыг. Та мэдэх байлгүй.

-За, би танд бичиг баримт олгоё гэж саная, та түүнийг яах болж байна?

-Эндээс явна.

-Хаашаа?

-Гэр рүүгээ.

-Москва руу юу?

-Москва руу.

-Танд Москва хориотой.

-Яагаад?

-Та ЗСБНХУ-ын АКЗ-ийн паспортны тогтолцооны тухай тогтоолын заалтад хамаарч байгаа юм. Та суух эрхгүй хэсэг хот бий. Москва түүний тоонд ордог юм.

-Үгүй, тэр тогтоол чинь шинэ Үндсэн хуулиас өмнө гарсан шүү дээ.

-Шинэ Үндсэн хууль Зөвлөлт засгийн хууль тогтоомжийг халаа-гүй. Зарим хууль, үгүй ээ, дүрэм гэх нь зүйтэй байх, жишээлбэл, сонгуулийн журмын тухай гэхчилэн, өөрчлөгдөнө, хянагдана. Харин пролетарийн диктатурыг хамгаалж байгаа хуулинууд хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Үндсэн хуулийн тухай нөхөр Сталины илтгэлийг та уншсан уу?

-Уншсан.

-Нөхөр Сталин “Шинэ Үндсэн хуулийн төсөл ажилчин ангийн диктатурын дэглэмийг яг ёсоор нь үлдээж байгаа” гэж шууд хэлсэн. Та үүнээс өөр яалгах гэв? Тэгж яривал, Үндсэн хуульд чөлөөтэй зорчих тухай заалт байхгүйг та анзаарсан биз, хөрөнгөтний үндсэн хуулинд “чөлөөтэй зорчих эрх” гэж голчлон томъёолдог шүү дээ, өөрөөр хэлбэл, оршин суух газраа чөлөөтэй сонгох, хүссэн газраа чөлөөтэй суурьших эрх. Тэнүүчлэхийг бид зөвшөөрөхгүй,

паспортны тогтолцооны хязгаарлалтыг халаагүй, ер нь халах ч үгүй биз.

Тэрээр цонх руу хараа буруулангаа,

-Харин ч болвоос улам чангатгана гэж бодож байна хэмээн учир битүүлэг нэмж өгүүлэв.

-За яахав, таны ярьж байгаагаар болог. Гэхдээ хүнийг ялны хугацаанаас ганц хоног ч атугай илүү хорьж болохгүй гэсэн хууль бий. Энэ хуулийг хэн ч халаагүй гэж Саша зөрөв.

-Тийм хууль та хаана харсан юм бэ?

-Уншиж байсан гэж Саша худлаа хэлэв.

-Тэр худлаа, тийм хууль байхгүй юм чинь та яаж уншсан байхав. Харин учир зүй бий: хоригдлын хугацаа дуусчихаад байхад түүнийг тавихгүй байна гэж саная, тэгвэл түүнийг ямар нэг үндэслэлгүйгээр хорьж байгаа хэрэг, өөрөөр хэлбэл, хууль бус үйлдэл хийж байгаа хэрэг.

-За тэгвэл, тэгээд л намайг тавьчих.

-Би танаас зуураагүй шүү дээ.

-Гэхдээ би бичиг баримтгүй яаж явахав.

-Таны бичиг баримт Красноярскт, ДЯАК-ын хязгаарын газарт байгаа. Зам харгуйг хэдэн мянган километрээр ярина, бас энэ нутагт цөллөгнийхөн хангалттай байгаа. Таны бичиг баримтыг яг нэгдүгээр сарын 19-нд ирүүлж амжсангүй, ирэх цагтаа ирнэ, та хүлээ. Хүлээх дургүй байгаа бол би танд Красноярск хүртэл нэвтрэх гэрчилгээ хийж өгье л дөө, тэнд очоод ДЯАК-ын хязгаарын газар очиж бичиг баримтаа нэхнэ биз. Харин тэд нар чухам ямар бичиг баримт өгөхийг би даан ч мэдэхгүй.

Энэ сүүлийн хэдэн үгэнд, хугацаа дуусгасан тухай бичиг баримт ч өгч магадгүй, эсвэл шинэ хугацаа товлосон тухай бичиг ч өгч мэднэ хэмээсэн сүрдүүлэг илт мэдэгдэв.

Саша чимээгүй азналаа.

-Тэгэхээр бичиг баримтаа эндээ хүлээх үү, араас нь Красноярск руу явах уу, өөрөө л сонго доо гэж Алферов дүгнэж хэллээ.

Саша нэг хэсэг бодож байснаа,

-Би өнөөдөр л суллагад ёстой. Суллахгүй бол нөхөр Калининд цахилгаан явуулна гэж хэлэв.

Алферов инээд алдав.

-түүнийг чинь тэр дор нь Калинины ширээн дээр аваачаад тавьчих уу?

-Мэдэхгүй. Гэхдээ хэн нэгэн хүн цахилгаанд хариу өгнө.

Алферов энэ удаа нүдээрээ инээмсэглэв.

-Та Сталинд бичсэн захианыхаа хариуг авсан уу?

За тэр. Сталинд бичсэн захиа нь, аягүй бол, мань хүний ширээнд байж байгаа байх. Тийм учраас инээгээд байх нь.

-Таны Сталинд захиа явуулдаг чинь зөв үү?

-Надад түүнд хандах эрх байхгүй гэж үү?

-Байлгүй яахав, мэдээж. хэн хүнгүй Сталинд хандаж байгаа, та сонин уншдаг юм чинь мэднэ. Ололт амжилтаа илтгэнэ, ажилд нь тусласанд талархана, удирдан жолоодож байгаад нь талархана. Ял эдлэж байгаа хүмүүс ч хандаж байгаа, тэр маргаангүй, тэгдэг хүн цөөн биш гэдгийг та ойлгож байгаа. Та ч бас хандсан. Харин хугацааныхаа талыг өнгөртөл гоморхож гомдоллоогүй чимээгүй байснаа гэнэт панхийлгэж! Ёс бус ял эдлэж байна, суллаад аль! Таны хэрэгт холбогдох шинэ нөхцөл байдал үүссэн юм уу? Үгүй, шинэ нөхцөл байдал үүсээгүй. Тэгээд харж байгаа биз дээ, танд хариу гэхээр юм ч ирээгүй. Хариу өгөхийн тулд хэргийг чинь дахин хянаж үзэх үндэслэл байх ёстой, гэтэл тийм үндэслэл ор байхгүй.

-Байхгүй бол байхгүй л биз. Гэхдээ хүн горьдох, найдах эрхтэй, тэр эрхийг нь хасч болохгүй.

Алферов аягаа цаашлуулж ширээгээ тохойлдоод, Саша руу нухацтай харав.

-хүн горьдох, найдах эрхтэй, тэр таны зөв. Гэхдээ хүн хийж байгаа үйлдлээ нягталж бодох ёстой, энэ бол түүний үүрэг. Таны захиа Сталинд хүрнэ гэж та нээрэнхээсээ бодож байсан уу? Хэргийг чинь дахин хянана гэж? Та нөхөр Сталинд хандсан төдийгөөс л үү? Үгүй ээ, та тэгж бодоогүй, тэгж найдаагүй. Та тэгж бодох тэнэг хүн биш. Энэ бол сайн бодоогүй үйлдэл. Нөхөр Сталинд захиа бичсэ-нээрээ та өөрийнхөө тухай, Панкратов гэдэг хүн байдаг тухай л холбогдох байгууллагад сануулсан, таны захиа тийшээ л очсон шүү дээ. Түүгээр зогсохгүй, таныг буруу ялласан гэж хуулийн байгуул-лагыг буруутгасан. Танд энэ хэрэгтэй юу?

Саша дуугарсангүй. түүний өмнө ямар хүн байна аа? Нөхөр үү? Дайсан уу? Нөхөр Сталинд бичих ёсгүй байсан, холбогдох байгууллагын дургүйг хүргэх хэрэггүй, өөр рүүгээ анхаарал татахын хэрэггүй энэ тэр гээд шууд хэлээд байх юм. Саша уул нь өөрөө үүнийг байнга ойлгож байсан шүү дээ. Тэгсэн хэрнээ биччихсэн.

-Магадгүй, бичих хэрэггүй байсан байх, гэхдээ нэгэнт бичсэн, аль хэдийн биччихсэн юмыг одоо ярих утга алга. Харин өнөөдрөөс эхлэн намайг цөллөгт хууль бусаар барьж байна. Энэ тухайд гомдоллох эрх надад гарцаагүй бий. Миний бичиг баримт танд хэзээ ирэхийг би мэдэхгүй, ерөөсөө ирэхгүй ч байж мэднэ.

-Суллагдлаа гээд та дээрдэх үү?

-Эрх чөлөө хэзээ ч шоронгоос дээр.

-Тэр зөв, эрх чөлөө шоронгоос дээр.

Алферов босч өрөөн дотуураа хэд алхаснаа түрүүчийн удаагийнх шиг шүүгээ рүүгээ очиж, галуун хүзүүтэй исгэмэл дарсаа хоёр хундагатай авчирч ширээн дээр тавилаа.

-За, Александр Павлович, та өнгөрсөн удаа надтай уухаасаа татгалзсан, одоо дургүйцэхгүй болов уу гэж найдаж байна. Тэр үед та захиргааны цөлөгдөгч, би харгис цагдаа нь байсан, одоо та, таны хэлж байгаагаар бол, эрх чөлөөтэй хүн юм байна, тэгэхээр ууж болох төдийгүй ер нь ийм өдрийг тэмдэглэх үүрэгтэй.

Тэрээр хоёр жүнзийг дүүргэснээ өөрийнхийгөө авч Саша руу толгой дохичихоод хөнтөрчихөв.

Саша ч өөрийнхийгөө уулаа. Исгэлэндүү ч гэсэн амтлаг дарс аж.

-За тэгэхээр, надад яах ч арга алга. Энд бичиг баримтаа хүлээ-гээд ёстой нэмэргүй, хүлээх хүсэл ч алга, дур ч алга. Красноярск хүртэл нэвтрэх гэрчилгээгээ хийгээд аль, тэнд очиж л хууль ёс, үнэн хоёрыг хайя.

-Надаас олоогүй юмаа тэндээс хайх нь хэмээн Алферов жуумалзан галуун хүзүүт рүү дохиж,
-Таалагдав уу? гэв.

-Амттай л рашаан байна.

-Дахиад нэг нэг яах уу?

-Болох л юм.

Алферов дарсаа ууж уруулаа шилэмдээд Сашаг ууж дуустал хүлээзнэв.

-Ингэхэд, та ийм юм болно гэж айхгүй байна уу? Нэгдүгээрт, таныг Красноярск хүргэх зардал надад байхгүй, та зардлаа өөрө даана, үнэтэйдүү л болох байх, хоёрдугаарт, яваад хүрчихлээ гэж саная, тэгээд ДЯАК-ын хязгаарын газарт очсон чинь, та яах гэж наашаа ирэв, таны бичиг баримтыг Кежма руу явуулчихсан, буцаж очиж нөхөр Алферовоос ав гэж хэлвэл яахав? А-аан? Юм ингэж эргэвэл танд аятайхан байх уу?

Саша хундагаа холдуулан Алферов руу ууртай харав. Бол оо! Өглөөний сайхан зугаа олж дээ, ажлаа алдсан золиг!

-Нөхөр Алферов!

Цаадах нь үгийг нь тасдав.

-Тэгж албархахын хэрэг юу байна? Та бид хоёр чинь ханиндаа юм балгасан шүү. Намайг Виктор Герасимович л гэл дээ.

Гэвч Сашагийн эгдүү нэгэнт хөдлөсөн учир мань хүн давтав:

-Нөхөр Алферов! Уучлаарай, иргэн Алферов! Энэ бол басамжилсан хоосон яриа. Цөллөгний хугацаа дууссан тухай гэрчлэх бичиг, эсвэл өгөхгүйн шалтгааныг дурдсан татгалзах бичиг хийж өгөхийг танаас албан ёсоор хүсч байна.

-Өө, тийм бий, та намайг ойлгосонгүй. Тоогүй хэрэг... Гэхдээ хэзээ нэгэн цагт ойлгоно оо гэж Алферов бодлогошрон өгүүлэв.

Тэрээр албаны өрөө болох хажуугийн тасалгаанд орж, ширээндээ суугаад, нэг хавгаст хэргийг сөхөн сөхөн байж баахан юм бичив. Тэгээд зочдын өрөөнд буцаж ирлээ.

-За тэгэхээр, Александр Павлович (мань хүн нэлээд ёгт байдалтай хэлэв), хугацаа дууссан тухай гэрчлэх бичиг чинь энэ, май. Энд “хааш нь явуулсан” гэсэн хүснэгт байна, хар даа. Би танд “Кежма” гэж бичсэн. Энэ бол та над дээрээс гараад шууд сэргийлэх рүү очно гэсэн үг, тэнд энэ бичигний оронд түр паспорт бичиж өгнө, гурван сарынх уу, зургаан сарынх уу, өгснийг нь л аваарай. Ямар ч асуулт битгий тавиарай. Паспортаа өнөөдөр, за хамгийн оройтлоо гэхэд маргааш авна, тэгээд яваад өг! Маргааш яг Тайшет руу шуудан явна, түүнд багтахыг хичээ. Нэгэнт Кежма руу явуулсан гээд бичиг хийчихсэн учраас би танд замын зардал өгч чадахгүй, яаж ийгээд болгоно биз, улаач танаас илүү мөнгө шулахгүй, чемоданаа чарган дээр нь хаячихаад, өөрөө явган дагаад алхчихгүй юу. Москва руу орохын хэрэггүй. Тусгай дэглэмгүй аль нэг хотод очиж түр паспортаа байнгынхаар солиулаад, дахиад нэг тийш, аль болохоор Москвагаас зайдуу газар руу яваад өгөх хэрэгтэй. хүн болгон зуун нэгдэх километрийн тэр рүү хошуурцгаадаг юм, тийшээ хэрэггүй байх, тэнд тань шиг хүн дэндүү олон байгаа, танд олны дунд байх нь зохисгүй, та с а л а н г и д байх хэрэгтэй. Танд илүүц холбоо сүлбээ хэрэггүй, ер нь танд ямар ч холбоо сүлбээ байх ёсгүй. Та эрүүл чийрэг, сайхан залуу. Нэг газар гурван жил ханатлаа суулаа, одоо эх болсон Орос орноороо жаал яв, орчлонг үз. Товчдоо, миний хэлснийг энэ удаа та ойлгох ёстой, миний зөвөлгөө танд хэрэг болох ёстой. Би таныг хуураагүй, бичиг баримт чинь Красноярскаас үнэхээр ирээгүй байгаа. Харин чухамхүү энэ учраас би таныг суллаж байна.

Түр чимээгүй болсноо учиртай нь аргагүй,

-Чухам энэ учраас бас яаруулж байна. Замдаа сайн яваарай! гэж нэмж өгүүлэв.

Алферов Сашагийн гарыг нэлээд удаан барив.

-Миний ярьсан бүх зүйлийг тогтоож аваарай... Үгүй, ингэхэд, та бид хоёр з ө в х ө н түүхийн бүтээлийн чинь тухай л ярьсан шүү. Тэгсэн биз дээ?

-Тэгсэн, зөвхөн тэр тухай ярьсан гэж Саша итгэлтэй хариулав.

Пятаков, Радек, Сокольников, Муралов нарыг болон большевик намын бусад нэрт зүтгэлтнүүдийг яллах шүүн таслах шинэ нүсэр ажиллагаа Москвад аль уржигдар эхэлчихсэнийг Саша яахин мэдэх билээ.

Харин Алферов бол мэдэлгүй яахав.

Энэ шүүх ажиллагаагаар 1937 он гараагаа авсан болой.

1984-1988. Переделкино.

Хоёрдугаар хэсэг

1

Саша Алферовынхоос шууд сэргийлэх рүү очиж түр паспорт авлаа. Хоёр нугалсан жижгэвтэр цаас. Овог, нэр, яс үндэс, төрсөн он, газар. Захиргааны цөллөгний хугацаа дууссан тухай гэрчилгээг үндэслэн олгов. Зургаан сарын дотор байнгын паспортоор соливол зохино. Бичээс нь ердөө л энэ.

Маргааш нь Саша үүрээр тэндээс хөдлөв.

Чарганы урд биенд шуудангаа бэржээнхээр тумлайдан ачиж, толгойг нь битүү ороосон хоёр охинтой нэг хүүхнийг араас нь түшүүлэн суулгажээ.

Сашагийн чемоданыг мөн тэр хавь руу нь шургуулсан аж. мань хүн өөрөө чарга дагаад алхлав. Морь нэгэн хэмээр гэлдрүүлж, хэвгий таарвал жаахан шогшино. Шогшихын үес улаач суудалдаа хөлөө унжуулан сууж, Саша чарганы соёоноос барьсхийн морины хэмээр шогшуулна.

Гэвч Ангарын эргээр өгсүүр, уруу газар ховор учраас тэр болгон гүйгээд байсангүй. Зөв талд тайга, солгой талд Ангар, мөрний нөгөө эрэгт, газар тэнгэрийн савслага хүртэл дахиад битүү тайга. Улаач морио элдэх буюу угзчихгүй яг зөнгөөр нь явуулж байна. түүний өртөөлөх Дворец хүртэл далан километр, хоёр өдрийн газар гэсэн үг, эдүгээ өдөр богинохон, шөнө явах аргагүй юм чинь тэгсхийгээд үдлэж, өөрснөө халуун юм гоочлох, бүлээцэх, мориндоо тэжээл өгөх хэрэгтэй. Саша Дворец хүрээд тэндээс Тайшет орохын тулд дахиад улаач олж тохиролцох ёстой болно.

Арван таван километр яваад, Недокура тосгонд улаачийн танилынд ирж үдэлцгээв. Дассан сурсан айл хоол унд дорхноо бэлдсэн ч нөгөө хүүхэн чарганаас буух, унтсан хоёр хүүхдийг гэрт оруулж тайчих, бие засуулах, идэж уух, дахиад хүүхдүүдээ хувцаслах, чарганд суулгах, өвсөөр хучих, дахаар тумлайдах энэ тэр гэсээр байтал яаж ийгээд бүтэн хагас цаг болчихлоо.

Саша үдлэх зуур замын хүүхнийг ажиглаж авав. Төрх байдал нь албан хаагч уу, эсвэл албан хаагчийн авгай юу гэхээр залуухан хүүхэн аж. Үстэй захтай пальто, ноосон даашинз энэ тэрийг үзэхүл районы аль нэг даргын авгай ч байж магадгүй. Улаач ч хүндлээд байх шиг.

Охидынх нь том хоолоо өөрөө идэж, хүүхэн багыгаа хооллох юм болсон чинь гар хуруу нь салгалан, жаахан шөл гоожуулсандаа уруулаа гэмшингүй хазаж, амныхаа алчуураар айлын ширээг арчиж барин бишгүй будлив. Саша улам ичээхвий хэмээн дэмий л хараа буруулна. Хүүхний хоолой нь царгиж, царай нь цонхийж гүрийгээд бие нь төдгүй юм уу, эсвэл толгойдоо хоосонгүй юм уу гэлтэй. Ерөөсөө ам нээхгүй, Сашаг бол өчүүхэн ч анзаарахгүй байснаа хооллож ундалсны эцэст гэрийн эздэд эелдэгхэн талархал илэр-хийлэв. Саша туслах санаатай бага охиныг нь гар дээрээ авсан чинь, хүүхэн “үгүй, үгүй” хэмээн яггүй сандарч, хүүхдээ бушуухан авав.

Энэ хүүхэн Кежмийн аль нэг даргын авгай мөн гэсэн Сашагийн бодол улам лавширч, өөрийг нь цөллөгний хүн гэж мэдэж байсан, эсвэл шууд ойлгосон учраас мань хүнээс дөлөөд байна гэж дүгнэв. Энэ бол шинэ зүйл! Саша районы дарга нар, тэдний авгайчуулыг танихгүй. Гэхдээ яг Кежмад сууж байсан цөллөгнийхөн аль нэг газар ажил хийдэг, хүн амьтантай, дарга цэрэгтэй уулзаж учирдаг, ярьж хөөрдөг, хэн ч тэднийг ад шоо үзэж хөөж туудаггүй байсан гээ биз дээ. Всеволод Сергеевич өөрт нь ингэж ярьсан юм чинь.

Гэтэл энэ хүүхэн түүнээс дүрвэх нь халаг байна. Бодвол, дээгүүр зиндааны нөхөртэй биз. Районы намын хорооны нарийн бичгийн дарга уу, захиргааны дарга уу.

Тэгж бодохоор бүр ойлгомж алга. Районы дарга нар чинь бүгд улаачтай, хос морин чаргатай, энэ хүүхэн юу гэж шуудангийн чаргаар явж байхав. Нэмэрт нь зам ийм байхад, жавар ийм байхад хоёр нялх хүүхэдтэй хүүхнээ ямар эр нөхөр ингэж явуулах вэ? Өөрөө Дворец хүргээд өгсөн ч чадах ёстой доо.

Недокурээс хөдөлцгөөлөө. Окуневка хүрч хоноглоно, гэгээтэйд амжих хэрэгтэй, тэр хүртэл арван найман километр. Улаач морины-хоо явдлыг жаахан нэмэв. Морио эцээхээс болгоомжлон шогшиход нь мань улаач суудалдаа суухгүй зэрэгцэн шогшдог болж. Саша ч түрүүчийн адил чарганы соёоноос барьсхийн даган шогшино.

Гэгээ ч байхгүй, утаа ч байхгүй, ёстой мөхсөн гэлтэй, цасанд дарагдсан жижигхэн тосгонд харанхуй болсон хойно ирцгээлээ.

Намхан адартай, харанхуй шахуу модон байшинд пийшингийн ханзан дээр хүмүүс унтацгааж байна. Хоёр охиныг тийш нь хэвтүүлэв. Сашад хучлага болгож уранхай огтор нэхий дээл пийшингийн цаад руу хаяж өглөө.

Саша харанхуйд гутлаа тайлж, пийшин дээр сэврээхээр тавиад, оймсоо бас нэг бүлээн газар руу шургуулж, нэхий дээлийг дэвсэн пальтогоо нөмрөөд хэвтэнгүүт нам унтжээ.

Өнөөдөр яггүй өдөр өнгөрлөө. Морины хөлд сийрэгшсэн замаар гучин гурван километр дулаан хувцастай, эсгий гуталтай алхлаа. Мозговоос Кежмад хүрсэн арван хоёр километрийг нэмэх юм бол бүр дөчин тав болчихно. Өглөөний дөрвөн цагт босон, Кежма хүртэл чемоданаа бас номнуудаа үүрч ирсэн, номоо орхиж тэвчээгүй, Москва руу илгээмжээр явуулахаар Кежмийн холбоонд тушааж амжсан.

Сашаг дөнгөж толгой тавив уу, үгүй юү сэрээх шиг санагджээ. Зуухны аманд гал гологнож, харанхуйд замын хүүхэн юмаа зэхэж, хоёр хүүхэд нь нойрмоглон гэншиж байна. Улаач чаргаа хөллөхөөр гарч буцаж ирээд, нэхий дээлээ тайлан өглөөний ундаа уучихаад, босч дахаа аваад бусдыгаа хүлээзнэв. Санаа нь зовохдоо байх суух газраа олж цөхсөн хүүхэн хүүхдүүдээ шавдуулан, Сашагаас төдийгүй гэрийн эздээс хараа буруулах ажээ.

Саша гурван жилийн өмнө Ангар руу үүгээр өртөөчлөн хүргүүлж явахад хүн амьтан эрхиш яриа хөөрөөтэй байсан билээ. Тэгэхэд мань хүн замынхаа хүмүүстэй унтахаар хэвгчихсэн байхад улаач, гэрийн эзэнтэй зөндөөн удаан сайхан хуучилж асан. Одоо бол нөгөө Недокурад ч, энэ Окуневкад ч яриа дэлгэдэг янз алга. Юуны учир энэ вэ? Ядарсаных уу? Замд ядарч,

эцэж цуцаад бушуухан орондоо орох гэсэндээ тэр үү? Эсвэл энэ гурван жилд зүгээр л дуу цөөтэй болцгоочихсон юм уу?

Тэг тэгсээр хөдлөцгөөв. Тэнгэр сайхан байна. Жавартай ч гэсэн салхи алга. Хорин километрийг төвөггүй шударч Сава тосгонд ирж үдлэн, түргэн зуур унд ууж, морио идүүлээд дахин цааш хөдлөж, нэгэнт шөнө болсон хойно Дворец хүрч ирлээ.

Саша харанхуйд тосгоныг таньсангүй. Гэхдээ өдөр ч байсан танихгүй л дээ. Гурван жилийн өмнө энд зуны цагаар ганцхан хоноод өнгөрсөн юм чинь. Соловейчиктэй голын эрэг дээр салснаас өөр юм ой тойнд үлдээгүй.

Улаач нөгөө хүүхнийг нэг харанхуй модон байшин руу аваачиж, хаалгыг нь тогшиж байж, хоёр хүүхэдтэй нь, юм хумтай нь оруулаад, буцаж ирэнгээ,

-Чи хаачих вэ? гэж Сашагаас асуув.

-Шуудан руу очдог байх даа. Тайшет орох унаа олох ёстой.

-Шуудан чинь хаачихсан.

Улаач чаргаа янзлан, өвс, дахаа эмхлэнгээ дурамжхан ярьж байгаа нь илт.

-Яаж ийгээд хүлээхээс.

-Хүлээх ч яахав, даарна биз дээ гэж улаач Саша руу харалгүй бувгнав.

Хөлдөж мэднэ гэдгийг Саша өөрөө ч ойлголгүй яахав.

-Комендантын газар руу очих юм уу, тэндхийн жижүүр та нар шиг улсыг явуулж өгөх ёстой гэж улаач хэлэв.

-Над шиг гэж хэнийг хэлж байна? хэмээн Саша шазруун асуув.

-Яахав, туугдсан улсыг.

-Би “туугдсан” хүн биш, би эрх чөлөөтэй хүн!

Сүүлийн гурван жилд мань хүн өөрийнхөө тухай анх удаа ингэж хэлж чадаж байна. Дуртай газраа хононо, дуртай зүгтээ явна, хэн ч түүнийг саатуулахгүй, бичиг баримтыг нь шалгаахгүй, шалгахгүй, цаашид ч шалгахгүй. Хар нэрнээс салах нь энэ! Комендантын газар очиж хононо, үгүйдээн тэнд сууж шөнийг барна гэдэг бол энэ байгууллага хувь заяанд нь хамаатай хэвээрээ байгааг хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Гайгүй ээ! Чемоданаа шуудангийн гадаа тавьчихаад, шуудан онгойтол тэр хавиар нь холхиод байдаг хэрэг. Юу гэж хөлдөх вэ, манаач нар хөлддөггүй биз дээ!

Улаач гэнэтхэн жолоогоо дугтарч чарга хөдлөхөд Саша дагаад явав. Улаач түүнийг нэг бэлэвсэн авгайн умгар байшинд аваачиж, тэнд бас нэгэн хагас нойртой шөнийг өнгөрөөв.

Тэр авгай ядмаг тарчигтаа боогдон, ганц рублиэс авахуулаад юухан ч болсон төлвөл хэнийг ч хамаагүй, хэзээ ч хамаагүй гэртээ оруулдаг бололтой.

Саша нэг рубль төлж, нэг муу нарийхан сандал дээр шөнөжин тарчлаад, өглөө болмогц ухасхийн босч, Тайшет орох унаа сурагла-хаар шуудан руу харайлгав. Тайшет руу шуудан маргааш явах аж.

Өчигдрийн улаач ирж, богцтой захиа, илгээмж бусад ачаагаа тушаалаа. Шууданг Тайшет хүргэх шинэ улаач ч бас ирлээ. Тэр нь Сашагийн танил, Соловейчик тэр хоёрыг гурван жилийн өмнө Богучанаас Дворец хүргэж ирсэн Нил Лаврентьевич болж таарав. Саша түүнийг дор нь таньжээ. Нүүр ам нь язганасан, хөл хөнгөн давжаа эр. Яг тэр жилийнх шигээ шуудангаа нэг бүрчлэн шалган тоолж, лац тамга энэ тэрийг нь хүртэл үзэж байна.

-Сайн байна уу, Нил Лаврентьевич гэж Саша баяртай мэндлэв.

Тэрээр ийнхүү уулзсандаа үнэхээр баярлажээ. Ямар ч атугай Ангараар цуг өгсөж явсан таньдаг хүн.

Харин Нил Лаврентьевич баярласан шинж огт алга, тэр ч бүү хэл Сашаг танихгүй буй царай гаргав. Үнэндээ таниагүй ч байж магадгүй. Тэгэхэд Сашаг зун харсан, одоо мань хүн нэхий дээлтэй, үстэй малгайтай, эсгий гуталтай байгаа, нөгөөтэйгүүр энэ гурван жилийн хугацаанд өвөл зунгүй Нил Лаврентьевич хичнээн хүнийг зөөсөн билээ, алийг тогтоох вэ дээ.

-Нил Лаврентьевич, та намайг санахгүй байна уу? Бид тантай уржнангийн цаад зун Ангараар наашаа, Богучанаас энд Дворец хүртэл цуг явсан, бас танай авгай хамт явсан, санаж байна уу? Та бид нар тэгэхэд Гольтявинод үдлэсэн, тэнд Анатолий Георгиевич, Мария Федоровна хоёр сууж байсан, санаж байна уу?

Нил Лаврентьевич Саша руу хялайж,

-Залуу, чамд юу хэрэгтэй юм бэ? гэж ширүүн асуув.

-Би Тайшет орох гэсэн юм, зөвхөн чемоданаа л дайна, өөрөө явган явчихна гэж Саша гэнэт сандарсхийн өгүүлэв.

-Чамд нэвтрэх бичиг байгаа юм уу?

-Юун нэвтрэх бичиг? Надад паспорт бий. Энэ байна.

Саша паспортоо гарган Нил Лаврентьевич руу сарвайв.

Цаадах нь паспорт руу хялайснаа,

-Паспорт бичиг баримт биш, паспорт юуных нь бичиг баримт байх вэ? Чиний хаашаа явах ёстойг тэнд тэмдэглэсэн байгаа юу? Чи, залуу, комендантын газраас нэвтрэх бичиг авбал таарна. Тийм гээч хүн Тайшет руу, эсвэл Тайшетаар дайрч явна гэх ухааны бичиг.

-Нил Лаврентьевич, нэвтрэх гэрчилгээг чинь цөллөгнөөс буцаж яваа хүнд өгдөг юм, та ойлгооч.

-Чи хаанаас явж байгаа юм бэ? гэж Нил Лаврентьевич дооглонгуй асуув.

-Тийм ээ, гэхдээ би түр паспорт авчихаад байна. Надад Кежма хүртэл нэвтрэх гэрчилгээ байсан юм, тэгээд тэндээс паспорт авсан, тэгэхээр би хүссэн газар руугаа явж болно.

Нил Лаврентьевич хариуд нь, зөвхөн тогтоосон газар руу явдаг хүнийг үзсэнээс биш дуртай зүгттээ явдаг хүнийг үзээгүй гэсэн маягтай Саша руу итгэл муутай харав. Эцэст нь,

-Комендантын газар оч гэж өгүүлээд богцтой шуудан руугаа эргэв.

-Нил Лаврентьевич, та ойлгож үз, тэр комендантын газар чинь надтай ярих ч үгүй. Та паспорттой, чөлөөт хүн, ажил явдлаа өөрөө шийд л гэж хэлнэ хэмээн Саша түүнийг ятгав.

Нил Лаврентьевич юу ч дуугарсангүй. Богц, боодолтой юм энэ тэрээ оролдоод эргэж ч харсангүй.

Сашагийн аюулхай руу эвгүй гөхөлзөөд явчихав. Анх удаагаа гэтлэшгүй доромжлолын айдсыг мэдэрч, ичих, жигших зэрэгцлээ. Алга нь хөлөрч, нуруу руу нь ч чийг даагаад ирэх шиг. Дэмий юмнаас болж энд үлдэх нь. Шуудан яваад өгнө, мань хүн хоцроно. Энэ нүхэнд зоогдчих нь. Тэгээд хичнээн удахыг бүү мэд. Комендантын газар руу очих нь утгагүй төдийгүй аюултай. Сайн бол “Танд паспорт байна, хүссэн газар руугаа явж болно, ажил явдлаа өөрөө зохицуул” гэж хэлнэ. Муудвал, хэн болохыг нь тодруултал барьж саатуулна, Алферовоос, аягүй бол Красноярскаас сураглана.

Алферов мань хүнийг танихгүй хотод паспорт хөөцөлдөх ярвигтай ажлаас, бас бус санаандгүй тохиолдлоос гэтэлгэхийг бодсон боловч энэ аглаг тайгад, Эрхүүгээс Красноярск хүртэлх, Ангараас Сибирийн их зам хүртэлх энэ зэлүүд нутагт цөллөгнөөс суллагдсан буюу нэг цөллөгийн газраас нөгөөд шилжиж байгаа хүмүүст нэвтрэх гэрчилгээ хэмээх цорын ганц бичиг баримт байдгийг бодолцсонгүй. Тийм бичиггүй л бол цөллөгний аливаа хүн-оргодол. Гэтэл оргодлын өмнөөс хариуцлага хүлээхийг хэн ч эс хүснэ. Авч явсан хүнийг оргоход дэм үзүүлсэн гээд х а м с с а н хэрэг тулгачихна.

Нил Лаврентьевичид өөрийгөө хэлсэн нь дэмий юм болох шиг

байна. Хэлээгүй бол түүнийг цөллөгт байсан гэж мэдэхгүй, томилолтын ч юм уу, магадгүй ямар нэг бүрэн эрх төлөөлөгч явж байна л гэж санана биз.

Үгүй ээ, Нил Лаврентьевич тэгж бодохгүй, томилолтынхон, бүрэн эрхт төлөөлөгчид ингэж царай алддаггүйг энэ егзөр толгой андахгүй, ямар гээч шонхор хажууд нь эргэлдээд байгааг дор нь гадарлачихна. Чухамхүү гадарлачихаад л холхон байсан нь дээр гэж бодож байхгүй юу, муу зальтай золиг.

Саша ийнхүү царайчилж, арчаагүй байгаадаа ичингүйрэвч,

-Та намайг энд үнэхээр хаячих юм уу? Нил Лаврентьевич! гэж гоморхон өгүүлэв.

Хоолой нь чичирч байна. Ичих, цөхрөх, гутрах давхцан яах ч учраа олохгүй шинжтэй. Нөгөө урт удаан хүлээсэн эрх чөлөө чинь ингээд хийсээд арилах нь, гишгих газаргүй болох нь, хамаг юм ёстой санаанд оромгүйгээр эргэх нь.

-За, яахав? Нил Лаврентьевич!

Нил Лаврентьевич нэг богц боочихоод цэгцэрч, Саша руу харснаа хараа буруулав. Гэхдээ тэрхэн хоромд лангууны цаана сууж байгаа бүсгүй рүү хяламхийжээ.

Саша дохионы учрыг ойлгонгуут тийшээ очоод, паспортаа сайхь бүсгүй рүү сарвайв:

-Бүсгүй ээ, би шуудангаар Тайшет хүрч болохсон болов уу?

Бүсгүй Сашагийн паспортыг эргүүлж тойруулж хэд харснаа буцааж өгөв.

-Та Нил Лаврентьевичтэй л ярьж тохир. Нил Лаврентьевич, та замын хүн авч явж чадах уу?

-Чарганы ачаа хэтэрчихээд байна.

-Би явган явчихна, чарга руу чемоданаа л хаячихъя, хариугүй хөнгөхөн чемодан гэж Саша өгүүлэв.

-Бидэнд мэдэл байх биш, ав гэсэн бол авна, яв гэсэн бол явна гэж Нил Лаврентьевич бувтнав.

Залины хүүдий! Заавал ингүүлэх ёстой юм гэнэ. Ухаан нь, энэ зорчигчийг хулгайгаар аваагүй, олны нүдэн дээр, эрх бүхий хүнийх нь зөвшөөрлөөр авч явсан болох нь.

Ийнхүү бүх юм шийдэгдмэгц Саша хулчгар зан гаргасандаа өөрөөсөө иччихэв. Юунаасаа айдаг байна аа? Аргаа барлаа гэхэд чемоданаа энд хаячихаад чарга дагаад алхчихна шүү дээ. Зам дээрээс арай хөөхгүй биз дээ.

Чемодангүй бол ёстой яг оргодол шиг болчихно гэдгийг Саша тэрхэн хоромд бодсонгүй.

Гурван чаргаар хөсөглөн хөдлөв. Түрүүчийн чарганд нөгөө хоёр хүүхэдтэй хүүхэн суулаа. Тэрээр Сашатай мэндлэх битгий хэл, түүний зүг харсан ч үгүй, ер нь хэн рүү ч харсангүй, хэнтэй ч юм ярьсангүй.

Ангарын эрэг дагасан замыг бодвол Тайшетийнх өргөн төдийгүй цас нь дагтаршсан аятайхан зам ажээ. Дор дороо амиа болгож яваа ч олуулаа учраас арай хөгжүүн гэлтэй.

Нил Лаврентьевичийн ачаа тийм ч их биш бололтой, мань өвгөн байсхийгээд дэлбэгчийнхээ суудалд сууна. Харин Сашаг ганц ч удаа суу гэсэнгүй.

Гурван жилийн өмнө Саша өвлөөр биш хавраар, энэ замаар биш, өөр замаар Ангарыг өгсөж билээ. Тэр өртөөний бүлгээс хэн хэн үлдсэн бол? Карцев нас барсан, Соловейчик тайгад алга

болсон байх. Володя Квачазед шинэ ял оноохоор Красноярск руу явуулсан, Ивашкин эсвэл “ангарчлагдсан”, эсвэл махан тээрэмд орсон, үгүй бол суллагдсан ч байж магадгүй. Гэтэл 58 дугаар зүйлтэй хүнийг амар тавих биш дээ.

Үгүй ээ, өөрийг нь суллагдихаад байна шүү дээ!

Яагаад чухам мань хүнд ийм аз таарав? Яагаад чухам мань хүн энэ горьдлогогүй тамын тойргоос гараад ирэв?

Алферов уу?

Гэхдээ мань хүнийг суллах ёсгүй бол Алферов өөрөө толгой мэдэн суллаж чадах уу? Тийм хариуцлага өөртөө хүлээх үү?

Үгүй л болов уу!

Тэгвэл юу байх вэ? Тохиолдол. Үгүй ээ, т э д э н д, т э д н и й ажилд тохиолдлын юм байдаггүй.

хэн нэгэн оролцов уу? Будягин? Марк?

Үгүй ээ, тэд нар т э г э х э д туслаж чадаагүй юм чинь о д о о бол бүр чадахгүй.

Тэгвэл, ямар ч атугай, Алферов уу?! мань хүн л болж таарах нь. Алферов байгаагүй бол мань Саша бусдын адил буруу замаар будаа тээх байснаас зайлахгүй.

Алферов өөриймсөг харьцаж байсныг энэ гурван жилийн турш Саша мэдэрсэн. Сүүний машин эвдэрсэн, тэр бол хорлон сүйтгэсэн хэрэг, ямар ч эргэлзээ байхгүй. Хамтралын даргыг олны өмнө доромжилсон, үүнийг Зөвлөлтийн засгийн ажилтны эсрэг өдүүлсэн алан хядах үйлдлийн үнэртэй хэрэг гэж болно. Зида хүртэл... Тэр хоёрын холбоог Алферов мэдэж байсан, өөрийг нь, үгүйдээн, өөр тосгонд шилжүүлэх ч юм уу, ямар нэг арга хэмжээ заавал авах ёстой байсан. Шилжүүлээгүй.

Алферов өөртөө л нүгэл хурааж байж. Сая бас дахиад азаа туршлаа. Юунд хөтлөгддөг юм бол? Саша нүдэнд нь дулаахан байдаг юм болов уу? Энэ тухай бодохын ч хэрэггүй! Алферов бол аливаа нялуурах сэрэл нь бөхсөн мэрэгжлийн чекист. ДЯАК-ын хязгаарын газрын зөвшөөрөлгүйгээр, 58 дугаар зүйлээр шийтгүүлсэн хүнд ялын хугацаа дууссан бичиг олгох... Одоо цагт хэн ийм зүрх гаргах вэ?..

Алферов өчигдөр өөрийг нь сулласан, гэтэл маргааш цөллөгт буй Панкратовын ялын хугацааг сунгасан тогтоол, эсвэл түүнийг хязгаарын газарт хүргэж ирэхийг тушаасан захирамж хүрээд ирэг. Тэгвэл Алферов яах вэ? Ямар тайлбар, яаж тавих бол?

түүний ийм аяг зангийн цаана юу байна вэ?

Улс оронд болж буй хэрэг явдалтай санаа нийлэхгүй байна уу? Хэрэв тийм бол яамны системээс гарах хэрэгтэй. Алферов ном энэ тэр бичдэг философчийг ч хэлэх үү, эрдэм

шинжилгээний ажилд очъё гэж лав гуйсан байх ёстой, зөвшөөрөөгүй л байх нь дээ, тэгээд энд чухамдаа цөллөгт байлгаж байгаа мэт барьж байна. Всеволод Сергеевич түүнийг “ирээдүйд бидний өрөөсөн болчих вий гэж зовох юм” хэмээсэн нь ортой л болов уу.

“Ирээдүйн бидний өрөөсөн” учраас ийм аяг зан гаргаж байгаа юм биш үү? Гарах газаргүйгээ ойлгоод сүүлчийнхээ хэд хоногийг х ү н ш и г өнгөрөөх гэж байх нь. Сашагийн тухай тушаал хожигдож, саатаж байгааг тохиолдлын чанартай зүйл гэж Алферов ойлгож байсан учраас Сашаг яаруулж, үгүйдээн эхний зургаан сар ч болохноо сэргийлэхтэй харгалдуулахгүйн учир шууд Кежмагаас паспорт шийтгүүлэн олгуулж дээ. Бас аж төрөхөд ер нь амаргүй байх болно гэдгийг Сашад ойлгуулж өгсөн.

Амьдрал амаргүй болох нь гэдгийг Саша бүр энүүхэн Дворец тосгонд л мэдэрч эхлэлээ. Улаач яагаад түүнийг цөллөгний хүн гээд мэдчихэв? Нүүрэн дээр нь нэг юм бичээтэй байх нь ээ дээ. хүн харахад мань эр дэндүү болгоомжтой, дэндүү хүнийрхүү байгаа юм болов уу.

Саша Тайшетын замаар хөсөгний араас алхлах зуур ийнхүү бодолхийлж явав. Эхний чарган дээр нөгөө дуугардаггүй хүүхэн яваа. Улаач нь гэж бас нэг дуу шуугүй өвгөн. Хоёрдах чарга дүүрэн ачаатай, түүнийг авч яваа хоёр эр нэг бол чаргандаа сууж, нэг бол араас нь зэрэгцэн алхана. Нил Лаврентьевич хоёрдах өдрөөсөө морио тэдний чарганы араас холбочихоод, өөрөө тэр хоёртой энэ тэрийг ярилцан явах болов.

Түрүүчийн чарганы чимээгүй хүүхэн Кежмийн районы намын хорооны даргын авгай гэдгийг Саша тэдний ярианаас олж мэдэв. Нөхрийг нь Красноярскт шууд хурал дээрээс баривчлаад явчихсан юм байж. Тэгээд л эхнэр нь хоёр хүүхдээ дагуулж Красноярск ч юм уу, Москва ч юм уу орж нөхрийнхөө талаар хөөцөлдөх, эсвэл өөрөө шоронд орчихгүйн тулд, хүүхдүүдээ алдчихгүйн тулд Оросын аль нэг зүг рүү, төрөл саднаа бараадан нуугдаж хоргодохоор ийнхүү явж байгаа аж. Бас Сашагийн ойлгосноор бол, зөвхөн тэр даргаар зогсоогүй бусад олон районы олон дарга, олон ажилтан нарыг барьсан гэнэ. Москвагаас нэг том дарга ирж, Красноярскт хязгаа-рынхныг хуралдуулаад, тэр хурал дээрээ “нөгөө дайснуудыг” шууд нэр цохон нэрлэжээ. Тэгээд “нөгөө дайснуудыг” хурал дээрээс шууд бариад Красноярскийн шоронд хийчихсэн юмсанж.

Харчууд хорссон, харууссан эсвэл тавласан, өрөвдсөн шинжгүй ярьцгааж явна. Тэгэх л хэрэгтэй байх нь, нөхөр Сталин тэгж л тушаасан байх нь, “эдүгээ цагт” орчлон ийм л байгаа юм чинь, үүнд нууц юм байхгүй, сонин ч юм байхгүй, ёстой үсгүй хусч байгаа юм чинь гэсэн царайтай. Сонин хэвлэл ч дайсны тухай л бичиж байна, хаашаа ч харсан эргэн тойрон дайснууд, хорлон сүйтгэгчид, баруун солгойгүй тагнуулдаж оросын ард түмнийг хоосруулж байна, хөдөө тосгоныг бол аль хэдийн хувхайруулж гүйцсэн билээ...

Тэд нар бараг долоо хоног явжээ. Сашагийн тэр жилийн Ангар өгссөн замыг бодвол энэ замд гацаа суурин элбэг, өдөр үдлэх, шөнө хоноглох тосгон мундсангүй. Өглөө, өдөр хоол ундаа тэгтлээ яарч сандрахгүй идэж ууж жаал сууцгаана. Гэхдээ баригдсан хоригдсон, цөлөгдсөн туугдсан амьтдын тухай мэдэж байвч юу ч эс ярина. Тайшет руу ойртох тусам хоригдол элбэгшиж, Сашагийн чихэнд өртсөнөөр бол Тайшетэд хорих анги олон, ой тайгаар бүгсэн оргодол босуул элбэг гэх бөгөөд замын аюул нэмэгдэн, явуулын улсын санаа сэтгэл тав алдах янзтай.

Тайшетэд бараг тулж очоод нэг тосгонд сүүлчийн шөнөө хоног-лов. Тайшетэд гэртэй зарим нь тэр чигээрээ яваад өгчээ. Анх гарсан гурваас гадна замд нийлсэн хэдэн чарганыхан тэр тосгонд хоножээ. Саша тэр тосгоны нэрийг ч мэдэж авч чадаагүй. Хүмүүсийн ярианаас Тайшетэд хүн амьтан чихээстэй байгаа гэдгийг л дуулжээ.

Тосгоноос өглөө эртлэн хөдөлцгөөв. Тайшет хүртэл 12-хон километр учраас чарганууд хөсөглөнө гэлгүй дор бүрдээ биеэ даагаад явцгаажээ.

Тайшетын наахан, гол замаас ой руу бас нэг зам салаалсан уулзвар дээр винтов буутай, ташууртай хоёр морьтон чарганы түрүүчийг зогсоолоо.

-Юу болчихоов, очоод мэдээтэх гэж Нил Лаврентьевич хэлэв.

Их, бага чарганууд зам дагаад цувраад зогсчихож. Саша тэдгээрийг зайчлан зарим газар замаас гарч цас туучуулан урагшлав. Яагаад зам хаачихав? хэн нэгнийг хайж байгаа юм болов уу? Бичиг баримт шалгаж байна уу?

Саша эхний чарга хүрч байж учрыг ойлгов. Тайшетаас хоригдлын цуваа наашилж явна. Гурав, гурваар эгнэсэн чимээгүй урт хар цуваа. Хоёр талаар нь буутай, нохой хөтлөсөн харгалзагчид.

Цуваа уулзварт ирээд зогслоо. Хоригдлууд одоо тов тодхон харагдаж байна. Хөвөнтэй цамц, уранхай пальто, эсвэл бүр ноорхой навгас хэдэрч, ганц нэгхэн хоригдол эсгий гуталтай, ихэнх нь савхин гуталтай, зарим нь бүр шидмэсээр боосон уранхай шаахайтай, сахал үсэндээ баригдаж, өлөн нүдлэсэн, ядарч зүдэрсэн амьтад. Саша энэ яваа насандаа ийм юм үзээгүй, үзэх нь битгий хэл төсөөлж ч яваагүй билээ.

Харгалзагчид цувааны хажуугаар хашгиран гүйлдэнэ:

-Дотогшоо! Икээ нь!.. Икээ нь!.. Икээ нь!.. Гар гараасаа барьцгаа! Икээ нь!.. Икээ нь!.. Икээ нь!..

Цуваа овоо эмхэрч, жигдэрч, нягтраад ирлээ.

Ноход сөөнгө дуугаар боорлон хуцна. Харгалзагчид бууныхаа бөгсөөр хоригдлуудыг түншинэ. Ой руу орсон зам саяны ирснээс нарийхан учраас тэднийг шахаж нягтруулж байгаа юм байна.

Команд цуурайтаж цуваа ой руу хөдлөлөө.

Сашагийн тоолсноор тавин хоёр эгнээ явж байна. Зуун тавин зургаан хүн гэсэн үг.

Цуваа өнгөрмөгц морьтонгууд араас нь хөдлөв.

Зам чөлөөлөгдөж чарга хөсөг ч явж эхлэв. Саша Нил Лаврен-тьевичийн чаргыг уулзварт ирэн иртэл хоригдлуудын араас харж зогслоо.

Сталин 1937 оны нэгдүгээр сарын 8-нд германы зохиолч Лион Фейхтвангерийг Кремльд хүлээн авч уулзав.

Ромен Роллан, Бернард Шоу энэ тэрийг бодвол юу шалихав. Гэхдээ өрнөдөд их нэртэй гэж мэргэжилтнүүд нотлон зүтгээд байгаа. Нацизмын дайсан. Францад цагаачлан суудаг хүн.

Зарим роман нь манайд хэвлэгдсэн. мань хүн “Еврей Зюсийг” уншиж амжсан, “Оппенгеймийн гэр бүл”-ийг гүйлгэж харсан, “Бэйсийн задарсан охин”-ыг жаахан эргүүлсэн. Шуурхай бичдэг эр. Гол сэдэв нь еврей, тэр учраас Гитлерийг үзэн ядна, Зөвлөлт Холбоот Улсыг нацист Германыг сөрөх гол хүч гэж үзэж талархан хандана. Тэгэхээр Пятаков-Радекийг шүүн таслах ажиллагааг зөв тайлбарлаж чадна, тэгэх ч ёстой. Энэ зорилгоор л хэрэгтэй хүн. Дэлхийн олон нийтийн санаа бодлыг бужигнуулах хэрэгтэй. Тэр өрнөдийнхэн ил шүүн таслах ажиллагааг хүсээд байсан, түүнийгээ авсан. Зиновьев, Каменевын хэргийг ил шүүсэн. Бас л итгээгүй. Тэгвэл одооны шүүх хурал дээр тэдний хүн орог л дээ. Тэгээд хараг, сонсог, гэрчлэг.

Сталин Фейхтвангерын тухай лавлагааг дахин уншив. Нас тавин хоёр. Мюнхенд хөрөнгөтөн еврейн гэр бүлд төрсөн, их сургууль төгссөн, дэлхийн дайнд оролцсон. Хөрөнгөтний сэхээтэн. Бүтээлийнх нь урт жагсаалтыг хавсаргажээ. Хэрвээ шүүн таслах ажиллагаан дээр очвол, хэрвээ зөв таниулж бичвэл бүх номыг нь хэвлэх юм шүү. Шагналыг нь ч сайн өгнө. Мөнгөнөөс хэн ч татгалзахгүй. Ялангуяа хөрөнгөтний сэхээтнүүд.

Пятаков-Радекийг шүүн таслах ажиллагаа саадгүй өнгөрөх ёстой. Үзүүлэх ажиллагааны амжилт юунаас хамаарах вэ? Юуны өмнө зөв с о н г о л т о о с. Шүүх хурлаар з ө в х ө н мөрдөн байцаалтын протоколд гарын үсэг зурсан хүнийг л шүүнэ. Яагаад гарын үсэг зурсан нь огт падгүй. Биеэр зүдэрсэн, сэтгэлээр унасан, төрөл төрөгсөдийнхөө өмнөөс айсан, амьд үлдэх хүсэлдээ автсан, яллагдаж байгаа ч намд үнэнчээ харуулахыг оролдсон энэ тэрийн аль нь ч падгүй. Ард түмэн хэргээ хүлээснийг нь л үнэмшинэ. Амжилтын өөр бас нэг нөхцөл: өнгөрсөн үеийн улс төрийн алдаа, ялангуяа тэр алдаагаа олон түмний өмнө гэмшиж байсан бол бүр сайн.

Яллагдагсад тэднээс шаардсан бүх юманд хэдийн гарын үсэг зурчихсан, мань хүн ч шүүх хурлыг нэгдүгээр сарын 23-нд эхэл гээд тушаачихсан байгаа. Тэрээр мөрдөн байцаалтын бүх протоколыг биечлэн хянаж, шаардлагатай засвар, нэмэлтийг өөрийн гараар хийж, улс төрийн үнэлгээг илүү тодорхой болгон, түүнийгээ үндэслэн шүүгдэгч нэг бүрт дүгнэлт өгсөн. Мөрдөн байцаагчид эрх зүйн мэдлэгээ харуулах гэсэндээ хуурамч зүйлийг булах гэж элдэвлээд байгаа. Шулуухан нь дээр! мань хүн Вышинскийд яг тэгж хэлсэн: “Олон юм яриулах хэрэггүй... Дор дор нь зогсоож бай. Олон юм чалчуулж болохгүй”.

Сокольников шууд бууж өгсөн. Эхний байцаалт дээр бултаж булзааруулах гэж оролдсон. Гэвч мань хүн байцаалтын протокол дээр ө ө р и й н х ө ө гараар “Сокольников английн тагнуулын албаны мэдээлэгч байсан” гэж бичсэн. Сокольниковт түүнийг үзүүлмэгц ямар зан аягтай байх ёстойгоо шууд ухаарсан, мань хүн уучлахгүй, тоглоом хийх бодолгүй юм байна гэдгийг

шууд ойлгосон. Ухаантай хүн. Эсэргүүцээд ашиггүй гэдэгт итгэсэн, түүний цохолтноос зөв дүгнэлт хийсэн, Зиновьев-Каменевыг шүүсэн хурлаас зөв дүгнэлт хийсэн, тэртэй тэргүй амьдрал нь дууссаныг ойлгосон. Эсвэл мөрдөн байцаалт гэж юу байхгүй гэдэг мэдсэн учраас айсан юм болов уу? Эсвэл залуу авгайнхаа хувь заяаг бодсон юм уу? Серебряковоос салгаж суучихаад одоо бэлэвсрүүлж хаях нь байна шүү дээ. Хэргээ хүлээсний жинхэнэ шалтгаан пад байхгүй. Мөрдлөгийн ажилд тус хүргэсэн гэдэг нь л чухал. Яг нарийндаа бол Сокольников энэ шүүн таслах ажиллагааны маш том бурхи. Пятаков, Радек хоёр илүү цуутай, харин ажилтны хувьд Сокольников хамаагүй дорвитой. Брестийн эвийн гэрээнд чухамхүү мань хүн гарын үсэг зурсан. Ийм ажлыг түүнд л даалгасан. Бусад яллагдагсадын дунд нэр хүндтэй. Нэр баастахгүй. Бухаринтай нүүрэлдэхийг хүртэл зөвшөөрсөн. Тэрээр энэ хэрэгт оролцохыг хүсээгүй, Бухарин одоохондоо ӨӨРТ нь найдаж байг. Кагановичид үүрэг болгосон. Тэгээд багын найз нар Кагановичийн өрөөнд уулзацгаасан. Сокольников ёстой дальдрах ч үгүй, хамаг юмыг Бухарин руу чихээд байсан гэж байгаа, цаад муу нь “Гриша, Гриша, чи юу ярьж байна аа, Гриша?” гэж дүлэгнэхээс цааш гараагүй. Инээдмийн жүжиг!

Пятаков дөнгөж гучин гуравхан өдөр тэссэн. Ер нь ч мань хүн Пятаковийн тухайд эргэлзэж байгаагүй. Бүр баригдахаасаа өмнө, алах ял заагдсан бүх хүнийг, түүний дотор хуучин авгайгаа өөрөө биечлэн буудаж алах зөвшөөрөл гуйж, энэ мэдэгдлээ хэвлэлд нийтлэхийг хүсэлт болгож байсан. Лениний нөгөө жолоодогч болно гэж гэрээслээд байсан хүн чинь одоо барлаг алуурчны албан тушаал царайчилж явах ч гэж. Тэгэхээр дотуураа хоосорч, яахаас ч буцахгүй, нэгмөсөн дүүрчихсэн хүн болсон нь тэр. Алуурчин, гүйдэгч гэж гуйж байгаа чинь цаашдаа эрх мэдэл горилохгүй гэсэн үг. Амьд явахыг л хүсч байгаа юм чинь яахаас ч буцахгүй, эцсээ хүртэл яахаас ч буцахгүй.

Серго Оржоникизе Пятаковын мэдүүлэгт үнэмшээгүй. “Яана гэнэ ээ? Миний туслахууд, мэрэгжилтнүүд, үйлдвэрийн дарга нар гээд миний өсгөж бойжуулсан хүмүүс хорлон сүйтгэгч, тагнуул болж байна уу? Тэр ёсонд хазгай! Би итгэхгүй! Нүүрэлдүүлэхийг шаардаж байна!” - “Өө, итгэхгүй байна уу?! Нүүрэлдүүлэхийг шаардаж байна уу?! Тэг л дээ! Бас Бухариныг дууд, цуг сонсог”. Пятаковыг авчирч. Зангиатай, хар костюмтай, зөвшөөрөл ч авахгүй тамхи татаад хэзээний өөртөө эрэмшсэн байдлаараа дажгүй харагдаж байж. “Тийм, би Троцкийтэй уулзаж байсан, би троцкийчуудын нэг”. Серго нүд нь орой дээрээ гарч, золтой л бөглөрчихсөнгүй: “Ардын комиссариатад чиний хүн олон бий юу?” Тэгтэл Пятаков “Миний хүмүүс чинийхээс олон” гэж хариулж. түүнд тал тохой татаж байгаа нь тэр. Серго ТЭР хоёрын харьцааг ойлгож. хүнд аж үйлдвэрийг малын эмч Серго биш, чухамдаа Пятаков удирдаж байгаа. Тэгээд мань хүн түүнд гайгүй явж ирсэн. Ноднин Пятаковын хөл муу хэвтэж байхад мань хүн эмнэлэг рүү нь эргэж очсон. Одоо юу шаардсанд нь гарын үсэг зурчихвал амь насыг нь өршөөнө гэж Пятаков тооцоолж байгаа. Гэвч Лениний гэрээслэлд нэр нь дурдагдсан хэнийг ч болов устгах ёстой. Пятаков одоохондоо найдазнаж байг. Хэргээ лавшруулаад хүлээгээд л байг. Алан хядах, тагнах, хорлон сүйтгэх үйл ажиллагаагаа хүлээсэн. Косиор, Постышев, Эйхе нарыг алахаар бэлтгэж байсан гэж Пятаковын мэдүүлэгт нэмж бичихийг өчигдөр Тэрээр Ежовт тушаасан. Наймдугаар сард Бухарин Рыков хоёрыг баривчлах асуудлыг Улс төрийн Товчоогоор хэлэлцэхэд тэр гурав эсрэг санал өгсөн юм. Яагаад эсрэг санал өгөв? Өөрсдийнх нь ээлж ирнэ гэж айгаад, өөрснийгөө аварч байгаа царай нь тэр. Одооны шүүх хурал дээр тэдний нэрийг хамсаатан гэдгээр бус золиосонд товлондсон хүмүүс гэдгээр дурдана. Тэгэхээр тэд нарын санаа амарч, шүүх хурлын дараа Бухарин Рыков нарыг

баривчлах саналыг дэмжиж таарна. Тэгж байтал өөрсдийнх нь ээлж ирнэ. Чубарь, Рузутак, Петровский гурав бас тэр хоёрыг баривчлахаас татгалзсан. Хөгшин толгой Петровскийд гар хүрэх хэрэггүй, хоёр хүүг нь буудаж алаад өөрийг нь аж ахуйн шалихгүй ажилд явуулчихад л бол оо. “Лениний ахмад гвардийн төлөөлөгч” маягаар, бас Төрийн думын хуучин депутат гэдгээрээ үлдэг. Пятаков зургууланг нь нэрлэх юм бол албадлага гэдгийг сэжиглэхнэ. Харин гурвыг нь тасдаад нэрлэвэл итгэл үнэмшилтэй болно. Цохиж гэмээ нь гарцаагүй цохих хэрэгтэй. “Бристоль” зочид буудал дээр гаргасан алдааг давгаж болохгүй. Энэ алдааг засах хэрэгтэй. Пятаков түүнийг засна. Троцкийтэй хилийн чанадад уулзаж байсан хүн юм чинь сайн ярьж өгөг, олон хэлтэй, боловсрол, мэдлэгтэй хүн юм чинь гарцаагүй үнэмшилтэй хувилбарыг бодож олог.

Радек... Шүүх ажиллагааны гол хүн гарцаагүй мөн. Өрнөдөд хамгийн их нэртэй нь. Фейхтвангер түүнийг чих тавин чагнах нь лав. түүнийг шүүх хурал дээр байна гэж мэдвэл Радек ёстой хэний ч хэлж чадахгүй юмыг хэлнэ.

Радек, мэдээж, зальт гайхал, гэхдээ үхлээ айчихсан байна лээ. түүнийг алхам тутамдаа шагшин магтаж, байдгаараа чармайж байгаа, Троцкийгээс захиатай ирсэн Блюмкинийг элдвийг бодож хойш таталгүй илчилж, Троцкийг зогсоо чөлөөгүй муулж ирсэн. Бас, хамгийн гол нь, түүний даалгаврыг биелүүлсэн. Ярвигтай даалгаврыг.

Сталин ширээн дээрх хавтаснуудаа ухаж байгаад Радекийн германуудтай хэлэлцээ хийсэн тухай илтгэлийг гаргаж ирэв. 1933 оны аравдугаар сарын 20, 24-нд Германы элчин сайдын яамны зөвлөх фон Твардовскийтэй, 1934 оны наймдугаар сарын 24-нд профессор Оберлендер, хэвлэлийн атташе Бауман хоёртой тус тус хэлэлцээ хийсэн тухай илтгэл. Энэ бол түүний даалгавраар хийсэн тандалт. Илтгэл Радекийн гарын үсэгтэй. Гэхдээ түүнд зориулагдсан гэх хаяг байхгүй. Тийм учраас германыхантай уулзаж ярилцаж байснаа шүүх хурал дээр яриг, Троцкийн даалгавраар тэгсэн гэдгээ хэлэг, тэгээд Троцкийн төдийгүй өөрийнхөө урван тэрсэлсэн үйл ажиллагааг нотлог. Зөрөөд байвал энэ баримтыг нь гаргаад ирнэ. Троцкийн даалгавраар биш, түүний даалгавраар хийсэн гэж зүтгэвэл хэн ч итгэхгүй, харин ч бузар гүтгэлэг гэж үзнэ, тэгж зүтгэж гэмээ нь Радекийн толгой ёстой тэсэхгүй. Хэлэх хэрэгтэй юмыг хэлбэл хар толгойгоо авч үлдэнэ. Тийм ам түүнд өгсөн. Юу хэлэх хэрэгтэйг мань хүн мэднэ. Гарамгай жүжигчин юм чинь. Ямар ч Фейхтвангер үнэмшихээр жүжиглэж чадна. Берлиний тухайд гэвэл тэнд ажилладаг Канделаки одоо яриа хэлэлцээг үргэлжлүүлж бай-гаа. Радек дээгүүр зиндааны дипломатуудтай уулзаж байсан бол Канделаки рейхийн гол удирдагчид болох Геринг, Шахт энэ тэртэй уулзаж байгаа. Ийм түвшинд Радек хэлэлцээ явуулах боломжгүй байсан. түүнийг Герман руу явуулалтай нь биш. Нэг удаа явуулсан чинь танигдахгүй хүн болох гэж алдарт хуузаа хусчихсан, хуузгүй буцаж ирээд Москвагаар нэг шуугиулсан. Арьсны эмгэг, нууц амрагийн шахалт гэхчилэнгийн албан бус цуу тараасан боловч мань годил өөрөө Польш руу явж ирсэн гээд ам алдчихсан. Гэхдээ олон хүн гадарласан. Тагнуул туршуулын мэдээнээс үзвэл ер нь их бурдаг этгээд, нацистуудын зохион байгуулах авьяас, тэр хөдөлгөөний сүр хүч, германы ард түмний урам зоригийг шагшин магтдаг гэж байгаа. Хэрээ мэдэхгүй лүд. Юмны учир бол шагшин магтахдаа биш, бодитой улс төрийн бодлогодоо шүү дээ. Харь орон гагцхүү найдвартай бөгөөд үнэнч холбоотон мөн бол таалагдаж болно. Герман о д о о х о н д о о холбоотон биш. Литвиновыг германыханд муу хэлсэн. хэн түүнийг тэг гэв? Литвинов, мэдээж, энэ яриа хэлэлцээний тухай мэдэхгүй,

мэдэх ч ёсгүй, мэдэхгүй чигээ-рээ үлдэнэ. Гэхдээ өөрийгөө товойлгоод байх хэрэггүй, өөрийгөө ЗХУ-ын гадаад бодлогын удирдагч юм шиг дүрслэх шаардлагагүй. Ердөө л д а л г а в а р б и е л ү ү л ж яваа хүн. Дипломатч биш. Канделаки хавьгүй дээр. Дахиад Радекийн хэрэг байхгүй. Германууд түүнийг ойлгоно, Радек хэдийн ойлгосон. Мөрдлөгийнхнийг хоёр сар арван найм хоног эсэргүүцэж байснаа амь насыг нь амлангуут сая нэг юм ойлгож, арван хоёрдугаар сарын 4-нөөс хэрэгтэй мэдүүлэг өгч эхэлсэн.

Хамгийн зөрүүд Муралов, Серебряков хоёр хэрэгтэй мэдүүлгийг бас яг тэр өдрөөс өгч эхэлсэн.

Муралов хамгийн удаан тэссэн. Долоон сар хагас.

Чанга бэлтрэг, “иргэний дайны баатар”, Троцкийн үнэнч хамсаатан.

Серебряков бас бараг дөрвөн сар зөрүүдэлсэн, бас л зөрүүд гай-хал. Ленин түүнийг “суут ажилчин” гэдэг байсан. Владимир Ильич ажилчин, тариачинд тийм магтаал хэлэх дуртай л даа. “Тогооч хүүхэн болгон улсыг удирдаж чадах ёстой”. Мөн гоё хэлж байгаа юм шүү. Гэтэл ямар тогооч улсыг удирдаж чадах юм бэ? Гал тогоогоо болгож байвал их юм. Гэхдээ тун сонсголттой. Бас улс төрийн хувьд ч ашигтай. Тэргүүлэгчдийн суудалд хэдэн эмэгтэй суулгачихлаа гэхэд бүх хүүхэн өөрсдийгөө тэнд суугаад улсыг удир-даж байна гэж санана. Дээд Зөвлөлд ч гэсэн саальчид, нэхмэлчдийг аль болохоор олныг оруулах хэрэгтэй. “Суут ажилчин” Серебряков! Шашны сургуулийн хоёрдугаар ангийн боловсролтой, слесарьч бил үү, токарьчин бил үү, гэтэл хар даа, -Суу билигтэн, ТХ-нд оруул! мань хүн Серебряковтой Өмнөд фронтод хамт ажиллаж байсан, гүйлгээ ухаантай, авхаалжтай, боломжийн эр, гэхдээ улс төрч биш, богино жолоотой учраас Троцкийтэй нийлсэн. мань хүн Серебряковт итгэл өгсөн, гэтэл Серебряков Троцкийтэй нийлсэн. Троцкийг мандаж явахад нийлснийг яахав гэж саная, ямар нэг юм горьдоо биз. Гэтэл сөрөг хүчнийг ялагдсан хойно? мань хүн түүнд шавраас гарах боломж олгосон шүү дээ. Бүр хорин таван онд, намын ХИУ их хурал дээр мань хүн түүнд “Зиновьевын сөрөг хүчнийхнийг ниргэхэд танай жигүүр бидэнд тусал” гэж хэлсэн. Хуучин дайчин нөхрөө хэмээн итгэмжлэн хэлсэн. Тэгээд хариуд нь юу сонслоо? “Бидэнд жигүүр байхгүй, бүх жигүүрийг татан буулгас-ныг чи мэднэ шүү дээ”. Мугуйд хариу, хуурамч хариу. Тэглээ ч гэсэн мань хүн хүлээцтэй хандсан: “Леонид, би чамтай чухал юм ярих гэж дуудсан юм. Чи ө в г ө н д миний саналыг дамжуулаарай”. Троцкий тэгэхэд 46-тай байсан ч түүнийг ө в г ө н гэцгээдэг байсан. мань хүн бас түүнийг ө в г ө н хэмээн тал засч, Зиновьев, Каменев хоёртой нийлчихвий гэсэндээ тэр хоёрын эсрэг холбоо байгуулахыг Троцкийд санал болгосон нь тэр. Троцкий, мэдээж, түүний далд санааг мэдчихсэн, юун төлөө Троцкий билээ дээ. Хариу ч өгөөгүй, ХИУ их хурлын турш юу ч дуугараагүй, Тэргүүлэгчдийн байранд годил шиг суугаад байсан, тэгснээ хойтон жил нь Зиновьев, Каменев хоёртой холбоотон болчихсон. За, Троцкий ч ойлгомжтой, түүнд өөр зам байгаагүй юм чинь. Харин Серебряков?! Нэгэнт хожигдсон тоглоомонд орох хэрэг түүнд юу байв? Нөгөө “суут ажилчин” гэсэн чинь тэр! Үзүүлсэн итгэлийг, түүний итгэлийг ойшоож чадаагүй. Одоо зовлонгоо эдлэж байна. Николийн толгод дахь зуслангийн хөрш прокурор Вышинский нь түүний зуслангийн байрыг аль хэзээний авчихсаныг мэдэхгүй байгаа даа. Серебряковыг баривчлах зөвшөөрөлд нэг гараараа гарын үсэг зурж байхдаа нөгөө гараараа ардын дайсан Серебряковын зуслангийн байрыг өөрт нь шилжүүлэхийг хүссэн өргөдөлд гарын үсэг зурсан. Хүсэлтийг нь ёсоор

болгосон.

Сталин Радекийн илтгэлийг хажуу тийш нь тавьж, цаасан дотроосоо Ежовын мэдээллийг гаргав. Бүх юмыг тодорхой бичжээ. Серебряковын зуслангийн том сайхан байрыг Вышинскийд өгч, түүний өгөршсөн муу байрыг Бородинд шилжүүлжээ. Бородин үнэнд нь Вышинскийд 38 990 рубль төлсөн байна. Гэтэл Вышинский энэ мөнгийг хоршоололд тушаахын оронд өөрийнхөө халаасанд хийчихээд, авсан байрныхаа үнэнд ерөөсөө юу ч төлөлгүй, тэр байраа прокурорын газраар дамжуулан үнэ төлбөргүй өөрийнхөө нэр дээр болгочихжээ. Залины хөрөнгө, луйварчин, нохойн гөлөг. Эрүүгийн хэрэгтэн. Гэхдээ намбатай. Орчлонд мөн янзын хослол байх юм даа. Европ маягийн хүн. Фейхтвангер болон гадаадын бусад бааснуудад аятайхан сэтгэгдэл төрүүлдгийг нь яана.

Улс төрийн шудрага зүтгэлтэн гэж байхгүй, байх ч ёсгүй. “Шудрага зан” гэдэг бол тээр тэндээс, хүн төрөлхтний нийтлэг эрхэм зүйл гэгчээс гаралтай эд. Гэтэл тэр нь жинхэнэ улс төрчид, тэгэх тусмаа жолоодогчид хэзээ ч таарахгүй. Жолоодогч бол хэрэглэж болох аливаа хүнийг ашиглана, гагцхүү тэгж байж түүхэн үүргээ биелүүлнэ. Жолоодогч хүнийг үнэлэхдээ түүний хүсэл зоригийг биелүүлэхэд бэлэн эсэх, чадах эсэх гэсэн ганцхан жишгийг удирдлага болгоно. Гэхдээ хамсаархах, солигдошгүй мэт авирлах санаархал байх ёсгүй. Гүйцэтгэгч хүн бусад бүх юман дээр хуурамч, худалч, зан суртахуунаар дорой байж болно. Тэгээд тэр этгээд хичнээн хуурамч, худалч, зан суртахуун дорой байна түүнээс ангижрахад төдийчинээ хялбар.

Поскребышев орж ирээд араасаа хаалга хаав.

-Таль ирлээ, Германы зохиолч Фейхтвангертай.

-Шууд оруулаарай гэж би танд тушаасан шүү дээ.

Поскребышевын царай хувьсхийгээд явчихав. Гэвч Сталиныг тийм шийдвэр өгөөгүй гэж хэлж эс зүрхлэв.

-Орцгоог.

Поскребышев хаалга нээж, Фейхтвангер, хэвлэлийн хэлтсийн эрхлэгч Таль хоёрыг оруулав.

Сталин Фейхтвангерийг тосон очиж гар барингаа түүнийг товчхон сонжин хараад, сурсан зангаараа суудал руу дохиж, ширээгээ тойрон нөгөө талд нь очиж суугаад, нүд рүү нь дахин нэг тогтож харснаа зовхио буулгав. Бүх юм ёсорхуу, илүү дутуу юмгүй, бараг хүйтэн цэвдэг гэлтэй. Инээмсэглэх, малилзах мөч болоогүй, ярианы явцад аяндаа тийм цаг ирнэ. Болгоомжлон цэрвүүлж, айлган сүрдүүлээд дараа нь эвийлж энхрийлнэ, энэ бол шалгарсан арга, ёстой лут үйлчилгээтэй.

Яах аргагүй еврей царай, хүрээгүй нүдний шил, дунд зэргийн нуруу, жавхалзсан байдал, халиун алаг халимаг, ялыгуй доровгор доод уруул.

Зорилт юу билээ? Энэ хүний аяыг олж өөрийн хүн болгоод, Холбооны ордон руу, шүүн таслах ажиллагаа руу явуулах. Тийшээ очвол сайнаар л бичиж таарна. Муугаар бичих юм бол түүний, өөрөөр хэлбэл, Гитлерийн гол өрсөлдөгчийн нэрийг гутаана гэсэн үг. Фейхтвангер ийм юм хийнэ гэсэн ном байхгүй. Зайлсхийхгүй л бол чухал, б и е ч л э н гэрчлэх нь л чухал.

Яриа эхлэхийг урьж Сталин Таль руу дохив.

-Ноён Сталин таныг сонсоё гэж байна хэмээн Таль германаар хэлээд солгой гарынхаа эрхий, долоовор хоёроор шодон сахлаа шувтрав. Ийм сахлыг юу гэдэгсэн билээ дээ? Мартчихаж.

Фейхтвангер Таль руу эргэсхийн ярьж эхлэв. Үгээн зөөн барин, магадгүй зарим үгийг давтсан байх, нэлээд дорвилог байрын урт юм хэлэв.

Таль товчхон орчуулав:

-Ноён Фейхтвангер таныг социалист нийгэм дэх зохиолчийн үүргийг хэрхэн төсөөлж байна вэ? гэж асууж байна.

Тэгээд сахлаа дахиад оролдов.

Ээ, чөтгөр чамайг, энэ бахлыг чинь юу гэдэгсэн билээ дээ?! Ер нь харьцангуй залуу хүнд бахлын хэрэг юу байна? Сахал бол эр хүний чимэг, эр зоригийн шинж, гэтэл бахал... хэн

хүнгүй бахлаа хусчи-хаад байхад энэ нөхөр салдаггүй. Бухарин, Рыков, Каменев энэ тэр бас бахалтай байсан, Ленинийг дуурайж байгаа царай нь тэр, бас Троцкийг. Бас Калинин бий, за тэр ч яахав, хөдвөр эр болж байгаа ухаантай юм. Харин Каганович ухаантай толгой, бахлаа хусаад сахлаа үлдээсэн. мань хүн нэг удаа түүний бахал руу харсан, Каганович ойлгосон учраас дор нь хусчихсан байсан.

-Аль ч нийгэмд зохиочдын үүрэг асар их хэмээн Сталин намуун дуугаар тогтуухан хэлэв. - Бид энэ үүргийг хүлээн зөвшөөрдөг, ач холбогдлыг нь ойлгодог. Зохиолч хэний талд байна вэ, харгис хүчинд зүтгэж байна уу, эсвэл дэвшилт хүчинд зүтгэж байна уу гэдэгт асуудлын гол нь байгаа юм.

Фейхтвангер түүнийг залган авч германаар ярихад, Сталин Гоголийн нэрийг сонсоод юун тухай ярьж буйг нь шууд ойлгов.

-За, тэгвэл, жишээ нь, Гоголь байна. Мөн чанараараа тэр харгис зохиолч байсан, гэтэл Зөвлөлт Холбоот Улсад түүний зохиолыг ихээхэн хэвлэж, их унших юм гэж Таль орчуулав. Таль зөвхөн Фейхтвангерт орчуулах буюу хэлснийг нь орчуулахдаа сахлаа орол-дож байгааг Сталин сая анзаарав. ТҮҮН рүү хандахдаа оролдохгүй байна. Үгүй, ингэхэд, юу гэдэг билээ дээ, чөтгөр алгадмарыг чинь?

-Зохиолчийн үзэл бодол нэг хэрэг, түүний нийгэмд гүйцэтгэх бо-дит үүрэг өөр хэрэг. Зохиолчид сайн философич байх нь тун ховор гэж Сталин хэлэв.

-Толстой гэж Фейхтвангер өгүүлэв.

Сталин дуугарсангүй. түүний үгийг тасдаж болохгүйг энэ герман мэдэж авбал таарна.

-Зохиолчид сайн философич байх нь тун ховор гэж Сталин давтан хэлэв. -Философчид сайн зохиолч байх нь ховор байдгийн нэгэн адил. Бидний хувьд Гоголийн хувийн үзэл бодол нь чухал биш, харин түүний зохиол бүтээлийн бодит үүрэг л чухал. Хаант Оросын хамжлагат ёсыг хайр найргүй шүүмжилж, буруушаасан байсан нь Гоголийн бодит үүрэг. Тийм шүүмжлэл бол дэвшилт шүүмжлэл. Бид энэ байгууллыг, энэ ёсыг халж, шинийг босгосон шүү дээ. Тэгэхээр манай хүмүүс, ялангуяа залуучууд, бид яагаад энэ нийгмийг устгасныг мэдэх ёстой.

Нөгөө хараал идсэн бахлын нэрийг “эспаньолка” гэдгийг мань хүн гэнэтхэн санав. Энэ муу хээнцэр Таль ямар золигийн бодлого бодуулав аа!

-Хуучин байгууллыг шүүмжлэх талаар Гоголь их юм хийсэн. Гэхдээ философчийн хувьд биш, уран бүтээлчийн хувьд, зохиолчийн хувьд хийсэн. Тийм учраас манай ард түмэн Гогольд хайртай, зохиол бүтээлийг нь үнэлэнэ ч, уншина ч.

Сталин чимээгүй болов. Зовхио нээхгүй суузналаа.

Фейхтвангер юм хэлэх санаатай Таль руу эргэсхийв. Таль толгойгоо Сталин анзаарахааргүй үл мэдэг сэгсрэв. Сталин чимээгүй болсон нь түр азналт гэдгийг Фейхтвангер ойлгов.

Сталин тэгж тэгж,

-Толстойн хувьд гэвэл, хэмээн ам нээв. -түүний философи нотолгоогүй зүйл болж таарсан. Германы антифашистууд эсвэл Испанийн бүгд найрамдахчууд муу хорын эсрэг хүч хэрэглэх ёсгүй гэсэн түүний онолыг хүлээн авч чадах уу? Чадахгүй. Толстой ард түмний аж амьдрал, түүнээс Наполеоны довтолгооны үед байгуулсан гавьяаг нээн үзүүлсний хувьд аугаа их уран бүтээлч, аугаа их зохиолч. Чухамхүү ийм жишээгээр, эх орноо хамгаалсан жишээгээр залуучуудыг хүмүүжүүлж байх ёстой. Харин Толстойн философи, түүний философийн зохиол бүтээл бидэнд сонин биш. Толстой сургаж сургамжилсан зүйл өөрийнхөө романуудад дэндүү их оруулдаг, тэгснээрээ тэр романуудынхаа уран сайхны үнэ цэнийг бууруулдаг.

Тэрээр дээшихнээ харав. Таль орчуулж байна. Фейхтвангер ойлгож буйгаа илэрхийлэн хаа нэг толгой дохин, ихэд хичээнгүйлэн сонсож байна. Талийг дуусмагц Фейхтвангер харцаараа дараачийн асуулт тавих зөвшөөрөл эрэлхийлэн Сталин руу харав. Тэгээд түүний царайнаас, түүний сөрөг харцнаас зөвшөөрлийн дохио олж харжээ. Ингэснээр тэр хоёрын хооронд сэтгэлийн холбоо үүссэнийг Сталин ч ойлгов.

Талийн орчуулснаар Фейхтвангер Сталины хэлсэнтэй санал бүрэн нийлж байна гэнэ. Гэхдээ Фейхтвангер энэ тухайд чухамхүү зөвлөлтийн зохиолчдын үүрэг юу вэ, тэд нар захирагч ангид заавал хамаарах ёстой юу, ертөнцийг үзэх коммунист үзэлтэй байх албатай юу, үг хэлэх эрх чөлөө, утга зохиолын эрх чөлөө Зөвлөлт Холбоот Улсад ямар байна вэ гэдгийг сонирхож байна.

-Зохиолчид бол сэхээтний нэг бүлэг, сэхээтэн бол анги биш, хөрөнгөтөн пролетари хоёрын завсар байгаа давхрага. Заримдаа хөрөнгөтөнд, заримдаа пролетарид үйлчилнэ. Гэхдээ, дахин хэлэхэд, зохиолчийн хувийн үзэл бодол нэг хэрэг, зохиолынх нь бодит үүрэг шал өөр хэрэг. Манайд аман дээрээ ажилчин ангийн төлөө, Зөвлөлт засгийн төлөө байдаг хэрнээ, түүгээр ч барахгүй намын гишүүн хэрнээ зохиол бүтээлээрээ пролетарийн ашиг сонирхлыг илэрхийлж чаддаггүй зохиолчид бий. Харин ч болвоос тэдний хуурамч зүүний баримтлал, тэдний хуурамч дэвшилт үзэл нь жижиг хөрөнгөтний орчин ахуйн тусгал болж байгаа юм. Гэтэл бас хөрөнгөтөн ангийн гаралтай, тэр ч бүү хэл, тайж язгууртны гаралтай хэрнээ зохиол бүтээлээрээ пролетарийн үйл хэрэгт үйлчилдэг зохиолчид байна. Авьяас билиг нь тэднийг түүхэн үйл явцыг ойлгох оргил өөд хөтлөн гаргасан хэрэг. Жишээ хайж хол явах хэрэггүй. Толстой, таны дурдсан биш, өөр Алексей Толстой гэж Октябрийн хувьсгалыг шууд хүлээж аваагүй, цагаачлан одсон гүн хүн, гэтэл тэр манай нийтийн үйл хэргийн төлөө яаж ажиллаж байна?! Сайн ажиллаж байгаа, тийм учраас түүнийг манайхан уншина ч, хүндлэнэ ч.

Сталин сурсан зангаараа намуухан дуугаар үе үе азнасхийн зугуухан ярилаа. Таль тэр завсар нь амжуулж орчуулж байв.

-Таны хэлснийг уран бүтээл нь пролетаричуудад үйлчилдэггүй зохиолчид зохиолоо хэвлүүлж чадахгүй юм байна гэж ойлгож болох уу?

-Үгүй ээ, тэгж ойлгож болохгүй, тэгж ойлгох нь буруу гэж Сталин шууд хариулав. - Фашизмтай дайтах бодит аюул бидэнд байна. Тэгэхээр зохиолчдын уран бүтээлд баатарлаг түрлэг голлох ёстой нь зүйн хэрэг, ард түмний оюун бодол, сэтгэл санаа, хэрэгцээ

шаардлагад баатарлаг түрлэг яг дүйнэ. Үүний зэрэгцээ баатарлаг сэдвийг бүр хөнддөггүй, уншигчдын тухай боддоггүй, уншигчдыг тоодоггүй, тэдний хэрэгцээ, дур, хүслийг тоодоггүй зохиогчид манайд бий. Уран бүтээл нь өргөн олон түмний ашиг сонирхолд нийцэх битгий хэл тэдэнд ердөө ойлгогддоггүй уянгын томоохон яруу найрагч манайд бий. Бид түүнийг хориглоно гэж үү? Үгүй ээ, бид түүнийг хэвлэдэг. түүнийг уншдаггүй нь бол өөр хэрэг. Уншдаггүй гэдэг чинь худалдан авдаггүй гэсэн үг хэмээснээ Сталин тамхинд идэгдсэн шар шүдээ гарган гэнэтхэн инээмсэглэж, -Танай тэнд, Өрнөдөд, гүйлгээгүй номыг хэвлэдэг бил үү? гэж асуулаа.

Тэгээд өөрөө хариулав:

-Үгүй, хэвлэдэггүй, ашиггүй юм чинь. Гэтэл бид хэдийгээр манай хэвлэлийнхэнд ашиггүй, алдагдалтай ч гэсэн хэвлэж байгаа. Нийтэлж байгаа. Сонирхогчдод зориулан. Хурмастынхныг шүтэн биширдэг хүмүүст зориулан.

-Гэтэл, жишээ нь, Андре Жид байна, зүрх гаргаж Зөвлөлт Холбоот Улсыг шүүмжилсэн, түүнийг танай хэвлэлд зүхэхийн цаагуур харааж зүхсэн гэж Фейхтвангер өгүүлэв.

Сталин босч, хивсэн дээгүүр зөөлхөн алхлан Фейхтвангерийн дэргэд очоод, түүн рүү долоовор хуруугаараа зааж,

-Андре Жидийн амыг барьсан хүн байхгүй. Харин тэр чинь энд байхдаа бүх юмыг тэнгэрт тулгал магтаж байснаа, нутагтаа буцаж очсон хойноо бүх юмыг газар дор ортол муулсан. Манай ард түмэн хоёр нүүртэнд дургүй. Манай ард түмэн үзэгдэж сонсдоогүй их хохирол хүлээж байж аугаа их улсаа байгуулсан болохоор гадаадынхан үнэнийг хэлнэ, аргагүй сүрлэг ололт амжилт олсныг нотлоно гэж гүндүүгүй найдаж байгаа. Ололт амжилтыг нь олж харахгүй мөртлөө үгүйсгэж, муулдаг хүнтэй манай ард түмэн яаж харьцах болж байна? Тийм биз дээ?

Фейхтвангер гэлбэлзэсхийн дал мөрөө хавчив.

-Та зөвлөлтийн хүний сэтгэл зүйг яг онож тодорхойллоо. Гэтэл өрнөдийн хүний сэтгэл зүй бол өөр, тэд сэтгэх эрх чөлөө, янз бүрээр сэтгэх эрх чөлөөнд дассан байдаг юм.

Сталин өрөөн дотуураа хэд алхаад дахин Фейхтвангерийн дэргэд ирэв.

-“Янз бүрээр сэтгэх эрх чөлөө”... Тэгвэл та яагаад манай шүүмжлэгчдэд гомдоллож байна? Андре Жид нэг санаа хэлж, манай шүүмжлэгчдэд өөр санаа хэлж. Энэ бол хараал биш, энэ бол утга зохиолын мэтгэлцээн. Өрнөдөд тийм мэтгэлцээн байхгүй гэж үү? Яаж хараалцдаг билээ дээ!.. Гэхдээ хэргийн учир бол өөр... Бид сар орчмын өмнө шинэ Үндсэн хуулиа батласан. Тэр хуулинд бидний юунд хүрэхийг х ү с ч байгааг бус, юунд х э д и й н хүрснийг, ю у г олж авч чадсаныг хэлсэн буй. Гол нь бид социалист байгууллыг бүтээж босгож чадсан. Бид ангийн эсрэг тэсрэг үл эвлэрэл, хүн хүнээ мөлжих ёс, олонхийн гуйланчлал, цөөнхийн тансаглал, ажилгүйдэл энэ тэрийг устгасан, хүн болгоны хөдөлмөрлөх, амрах, боловсрол эзэмших, эмнэлгийн үйлчилгээ авах гэхчилэнгийн эрхийг хэрэгжүүлсэн, ястан арьстны болон үндэстний тэгш эрхийг хэрэгжүүлсэн, эцэст нь хэлэхэд, жинхэнэ ардчиллыг

хэрэгжүүлэн хангасан. Ж и н х э н э гэдгийг цохож хэлье!

түүний хуруу Фейхтвангерийн цээжийг шүргэлээ.

-Өрнөдөд иргэдийн тэгш эрхийн тухай ярьдаг, гэтэл асуулт гарч байна, эзэн ажилчин хоёрт ямар тэгш эрх байх вэ? Өрнөдөд үг хэлэх, хурал цуглаан хийх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний тухай их ярьдаг, гэтэл ажилчдад хурал хийх байр, хэвлэх үйлдвэр, цаас гэхчилэн байхгүй юм чинь тэр эрх чөлөө нь хоосон цууриа. Манай үндсэн хууль энэ эрх чөлөөг материаллаг хэрэглэгдэхүүнээр хангаж байгаа юм. Чухам энэ бол социалист ардчилал, чухам энэ бол бидний ойлголтоор эрх чөлөө. Иргэншсэн ертөнцийн шилдэг хүмүүсийн ардчилсан хүсэл тэмүүлэл рүү фашизм нулимаж байгаа одоон цагт манай үндсэн хууль фашизмын эсрэг ялын төлөвлөгөө болж байна. Харин хөрөнгөтний эрх чөлөө бол зохиомол зүйл. Танай парламентат тогтолцоо Гитлерт хориг болж чадсан бил үү? Үгүй, чадаагүй. Танай сайд нар фашизмтай тэмцэхийн оронд парламентэд депутатуудын дэмий балай асуулгад хариулж цагаа үрж байсан. Тиймгүй гэж үү?

-Энэ ч гарцаагүй тийм шүү хэмээн Фейхтвангер зөвшөөрөв. -Өрнөдөд үүнийг олон хүн ойлгож байгаа. Гэхдээ би илэн далангүй яривал та болгоохсон болов уу?

Таль орчуулав.

-Бодож байгаа юмаа хуу ярь гэж наадахдаа хэл. Юу л хүссэнээ асууг. Үүнийг наадахдаа сайн тайлбарлаж өг! Аль болохоор эелдэг!

Таль бахлаа илбэн шувтарч, онцгой дорвилог дүр эсгэн байж Сталины хэлснийг орчуулав.

-Баярлалаа хэмээн Фейхтвангер царай нь гэрэлтээд явчихав. -Тэгвэл би хэлэх гэж бодож байсан юмаа шууд хэлчихье: Зөвлөлт Холбоот Улсын нийгмийн байгууллыг социалист хүмүүнлэг ёсны эрхэм оргил хэмээн үзэж байсан танай олон анд нөхдийг Зиновьев-Каменевыг шүүн таслах ажиллагаа мухардалд оруулсан. Зиновьев Каменев хоёрыг оносон сум шинэ ертөнцийг хамтад нь хөнөөсөн юм шиг тэдэнд санагдаж байгаа. Тэр хоёр чинь хувьсгал хийсэн, шинэ байгууллыг батлан тогтоосон улс шүү дээ.

Сталин чухамхүү энэ асуултыг хүлээж байсан хэрнээ сонсонгуут хэрдхийн цочив.

Фейхтвангер Сталиныг балмагдахын чинээ санаагүй учраас ихэд гайхшран түүнийг харзналаа.

Сталин эргэж өрөөн дотуураа хэд алхалснаа Фейхтвангер рүү харалгүй ярьж эхлэв.

-Иргэний дайнд сайн дайтсан хүмүүс бүтээн босголтын үед тэр болгон хэрэг болохгүй юм. Тэгсэн хэрнээ гавьяа зүтгэлдээ дулдуй-дан өндөр албан тушаал горилно. Тэд тэр албан тушаалаа авсан. Гэтэл барагтайхан ажилтан гэдэг нь харагдсан. Яах вэ? Тэнцэх ажилд нь тавихаас өөр аргагүй болсон. Нөгөөдүүл чинь гомдоод намын чиг шугамыг эсэргүүцэгчид болон хувирч, намтай, улстай, ард түмэнтэй ил тэмцэл явуулахдаа хүрч шалдаа буусан.

Тэрээр түр чимээгүй болов.

-Энэ бол нэг янзын хүмүүс. Өөр нэг янз нь чадварлаг, авьяаслаг хүмүүс. Тэдний дунд гол хүн нь Троцкий. мань хүн хэзээ ч большевик байгаагүй. Энэ тухай Ленин удаа дараа хэлж ч байсан, бичиж ч байсан. Тэрээр Октябрийн хувьсгалд наалдаж нийлсэн, тэмцлийн үед нэмэртэй, тустай байсан, хэн ч түүнийг үгүйсгэж чадахгүй. Гэтэл төлөвлөгөө тооцоотой тайван ажил хийх чадваргүй юмсанж, түүх түүнийг өөр сууринд шилжүүлсэн, мань хүн түүхийг сөрөх гэж оролдоод бүр гадна нь хаягдчихсан, ард түмэн түүнийг улс орноосоо хөөж явуулсан, уул нь өөрийгөө ж о л о о д о г ч гэж үздэг хүн шүү дээ. Тэгээд хилийн чанадад гарсан хойноо балмад хэрэг өдүүлж эхэлсэн. Эргэж ирж, засгийн эрхийг буцааж авах зорилт өөртөө тавьсан. Ямар ч үнээр хамаагүй, гэхдээ заавал авах зорилт. Түүнээ биелүүлэх гэж их даварсан.

Сталин дахиад Фейхтвангерийн өмнө зогтусч, хуруугаа гозойлгон, нүд рүү нь эгцэлж хараад,

-Да-вар-сан... гэж давтан өгүүлэв.

Тэгснээ хөмсгөө зангидан үргэлжлүүлэв.

-Троцкийн хамтран зүтгэгчдийн тухайд гэвэл тэд түүний талын-хан чигээрээ үлдэцгээсэн. Тэд гэмшицгээсэн, нам тэдэнд итгээд төрийн өндөр албан тушаалд томилсон, гэтэл тэд намыг мэхэлсэн, тэд Троцкийг удирдлагад буцааж оруулахыг санаархан нөгөө толгойлогч шигээ бас их даварсан.

Тэрээр өрөөн дотуураа холхих зуур яггүй харамссан дуугаар цааш нь ярив.

-Арван жил! Арван жил бид тэдэнтэй ноололдлоо. Өршөөгөөд л буцаагаад тавьчихна, тэд дахиад л биднийг хуурчихна, бид дахиад л өршөөнө, дахиад л өндөр албан тушаалд итгэл хүлээлгээд тавина, тэд нар бидний ар худрагаар хуйвалдаан, далд явуулгаа зэхэж бай-сан байгаа юм, Кировыг алсан, бусад удирдагчийн аллагыг зохион байгуулсан. Хэдий болтол тэвчих вэ? Ард түмэн цаашид тэвчиж чадахгүй!

Фейхтвангер асуулт тавих зөвшөөрөл горилон Таль руу чимээгүй харав.

-Нөхөр Сталин, ноён Фейхтвангер танаас юм асуух гэнэ хэмээн Таль дүлэгнэн өгүүлэв.

-Тэгэг л дээ гэж Сталин эргэж харалгүй бувгнав.

Таль Фейхтвангерийн асуултыг хөрвүүллээ:

-Зиновьев-Каменевын хэргийг шүүхэд эд мөрийн нотлох баримт сох байгаагүй нь өрнөдийн хүмүүст ёозгүй сэтгэгдэл төрүүлсэн.

Сталин инээд алдан толгой сэгсрээд, суудалдаа суув.

-Бичгийн нотолгоо гаргаж ирэхийг шаардаж байгаа юм уу? Яасан гэнэн хүмүүс вэ! Башир хуйвалдагчид чинь өөрсдийгөө илчлэх бичиг баримт хэзээ ч хадгалдаггүй юм. Гэхдээ тэдэнд

гэрчийн мэдүүлэг, нотлох баримт хангалттай олныг тулгасан. Мөрдлөгийн явцад материалыг хянуур нягт шалгасан, шүүх хурал дээр өөрснөө хүлээж түүний үнэн зөвийг бататгасан. Болж буй хэрэг явдлыг бүх ард түмэн ойлгоосой гэж бид хүссэн юм. Тийм учраас шүүн таслах ажиллагааг дээд зэргээр тодорхой, дээд зэргээр энгийн байдлаар зохион байгуулсан. Элдэв баримт, гэрчийн мэдүүлэг, мөрдөн байцаалтын янз бүрийн материалаас дэлгэрэнгүй ишлэх нь хуульчид, эрүүгийн хэргийн мэрэгжилтнүүд, түүхчдэд сонин байж болно, харин ийм олон нарийн ширийн юм бол жирийн иргэдийн толгойг эргүүлэхээс цаашгүй, тэдний хувьд яллагдагсад хэргээ гарцаагүй хүлээх нь элдэв цааснаас хавьгүй олон зүйлийг хэлж өгнө. Илэн далангүй байцгаая л даа: манай шүүхийг хуурамч гэж үзэж байгаа хүмүүс хуурамч шүүгч нар хуурамч баримт бүрдүүлж чадна гэдгийг маш сайн ойлгож байгаа. Хуурамч баримт бүрдүүлэхэд тийм төвөгтэй биш. Гэтэл манай шүүх хуурамч шүүх биш, шудрага шүүх. Тийм шүүхэд хуурамч баримт хэрэггүй. Ард түмэн ойлгох хянан таслах ажиллагаа л хэрэгтэй. Одоо болох шүүн таслах ажиллагаа ч бас өргөн түмэнд ойлгомжтой болно гэж би найдаж байна. Фашизмтай нэгийгээ үзэх аймшигт дайн нүүрлээд байхад ард түмэн дотоодынхоо дайсныг мэдэж байх ёстой, тэднээс өөрийгөө сэрэмжлэн хамгаалж чаддаг байх ёстой. За, тэр Радек байна, нэр цуугай, хурц ухаантай, ёстой гялалзсан хүн, би түүнд их дотно нөхөрсөг ханддаг, баараггүй итгэдэг байсан... За... гэснээ Тэрээр ширээн дээрх хавтсаа нээж хэдэн хуудас гаргав. -За түүний шоронгоос бичсэн захиа энэ байна, арван хоёрдугаар сарын 3-нд бичсэн байна, харж байгаа биз дээ, их урт захиа, мань хүн ямар ч гэм буруу байхгүй гэж энэ захиан дотроо андгай тангараг тавьсан байна... Гэтэл энэ... хэмээн Сталин өөр хэдэн цаас гаргаж ирэв. -Энэ бол түүний мэдүүлэг, эндшээ бүх юмаа хүлээн зөвшөөрсөн байна, арван хоёрдугаар сарын 4-нд гарын үсэг зурсан зүйл. Худлаа хэлсэн захиа надад явуулчихаад маргааш нь гэрчийн мэдүүлэг, бусад илчлэх баримтнаас хаашаа ч бултаж чадахгүй бүх хэргээ улайсан байгаа юм.

Сталин бодлогошрон Фейхтвангер руу харснаа,

-Еврейчүүд та нар Иудагийн тухай мөнхийн домог бүтээсэн хэмээн сэтгэл уярам өгүүлэв. - Гэтэл бид тэр Иудануудтай чинь үзэлцэж байна. Манай амьдрал ахуйг та шимтэн ажиглаарай, олон зүйлийг олж харна. Та манай энд удах уу?

-Би хоёрдугаар сарын дунд хүртэл зөвшөөрөлтэй.

-Маш сайн байна. Эрүү шүүлт, ховсдолт, төлөөний жүжигчид энэ тэр гэгчийн тухай элдэв үлгэр домог Өрнөдөд зохиодог. Яая гэхэв, Радекийн хэргийг мөрдөж дуусч байгаа, шүүх ажиллагаа энэ сард эхлэж магадгүй гэж надад хэлсэн. Яг өдрийг нь би мэдэхгүй, тэр бол шүүхийн мэдэх ажил, шүүх манайд хараат бус, зөвхөн хуульд л захирагдана. Гэхдээ миний мэдэж байгаагаар бол, шүүх хуралдаан өмгөөлөгчтэй, ил болно гээд Таль руу дохиж, -Танд тасалбар олж өгөхийг нөхөр Талиас хоюулаа хүсье. Тэнд очиж, чихээрээ сонсож, нүдээрээ үзэхгүй юу. Дуртай орчуулагчаа дагуулж очоорой. Нөхөр Таль, та ноён Фейхтвангер тасалбар олж өгч чадах болов уу? гэж асуув.

-Хичээе ээ.

-түүнд хэлж өг дөө.

Таль орчуулав.

-Баярлалаа хэмээн Фейхтвангер балмагдан өчив. -Би уул нь...

-Зүйтэй, маш сайн байна гэж Сталин үгийг нь тасдав. -Манайд “Зуун удаа сонссоноос нэг удаа үзсэн нь дээр” гэсэн үг бий. Та, тэгэхээр, нүдээрээ үз.

-Би уул нь, таныг болгоовол, бас нэг юм асуух гэсэн юм...

-Бололгүй яахав. Ярилцах л гэж бид уулзсан шүү дээ хэмээн Сталин тааламжтай хариулав.

-Тэгэхээр юу л даа, бид, Өрнөдөд, улс орныхоо удирдагчдад жирийн хүн шиг хандаад сурчихсан юм. Харин танайд бол жолоодогчийг шүтэх явдал бурханчлан бишрэх хэмжээнд хүрч, тэгээд түүнийгээ... хэмээн Фейхтвангер оновчтой үг хайж түгдэрснээ, -Намайг өршөөгөөрэй, дэндүү болхи илэрхийлэх нь элбэг байх юм гэв.

Сталин инээд алдав.

-Болхи ий?.. гээд Тэрээр дал мөрөө хавчив. -Жирийн ажилчин, тариачид хэзээ, хаана боловсон ёсонд суралцахсан билээ? Тэд нар шинэ нийгэм байгуулж байна, хүнд нөхцөлд хүнд ажил амжуулж байна, тэдэнд боловсон ёсонд суралцах цаг байхгүй. Улаан талбай дээр хөдөлмөрчдийн жагсаалын үеэр мянга мянгаар барьж яваа сахалтай хүний том том хөргийг би өөрөө ч гэсэн аль хэзээний үзэж чадахаа болиод байгаа юм. Үзэж чадахгүй байгаа хэрнээ хараад байгаа, харахаас өөр арга байхгүй, ард түмнээсээ хараа буруулж, тэдэнд ууцаа харуулалтай нь биш.. Би мөхөсдөөд байна, би ард түмний олзны хүн.

-Гэтэл, хэмээн Фейхтвангер зөрөв. -Боловсон ёс мэдэх хүмүүс хүртэл яг адилхан тийм юм хийж байна. Тэднүүс таны биечлэн ямар ч холбогдолгүй газарт хөрөг, цээж баримал энэ тэрийг чинь тавих юм. Жишээлбэл, Рембрандтын бүтээлийн үзэсгэлэнгийн магнайд таны цээж баримал байх юм. Нэг л ойлгомж муутай зүйл... Рембрандт арван долдугаар зуунд амьдарч, туурвиж асан хүн.

-Тэднүүс бол зөвлөлт засгийг тээр өнгөрсөн хойно хүлээн зөвшөөрсөн хүмүүс хэмээн Сталин дошгиров. -Сэтгэл дотроо одоо хүртэл хүлээн зөвшөөрөөгүй ч байж мэднэ. Одоо болохоор үнэнч гэдгээ нотлох гэж амиа тавих нь халаг. Тийм учраас юмны хэр хэмжээг мэдэхгүй... Нэг зуйрган тэнэг толгой хэдэн зуун дайснаас илүү хор уршиг тарина.

Тийм асуулт тавьсанд мань хүний дургүй хүрчээ. Зохимжгүй асуулт. Тиймээс түүний дургүй хүрнэ гэдэг юу байдгийг энэ муу шорвог герман мэдэрч авах ёстой. түүний дургүй хүрснийг тэр муусайн эргүү зуйргануудад хамааруулах нь лав. Гэхдээ түүний хилэн гэж юу болохыг ойлгож авна.

Фейхтвангер уйман, түүнээ нуух гэсэндээ шилээ илгэн даавууны өөдсөөр арчин цөхөрч буйд сэтгэл ханасан мань хүн түүнээс тугалган харцаа салгахгүй байснаа, бөглүү намуухан хэрнээ хэрцгий дуугаар цааш нь үргэлжлүүлэв.

-Энэ чинь зүгээр нэг зуйрган тэнэгүүд биш, зориудын хорон санаатнууд байж мэднэ. Ийм аргаар намын удирдлагыг гутаах гэсэн хорлон сүйтгэгчдийн зориудын хорон санаа гээд Сталин Таль руу хандаж, -хэн үүнийг зохион байгуулсныг өнөөдрийн дотор тодруул, тэгээд буруутныг нь шийтгэ. Наадахдаа орчуулж өг гэв.

Таль ёсоор болгов.

-Би тэгүүлэх гэсэн юм биш шүү, надаас болж хүмүүс шийтгүү- лэхийг би огт хүсэхгүй байна хэмээн Фейхтвангер бүр айчихаж.

Сталин хэсэг зуур бодолхийлснээ, Тальд хандан хайнга дуугаар,

-За яахав, ноён Фейхтвангерийн хүсэлтийг хүндэтгэж үзье. Үзэсгэлэн дээрээс нөхөр Сталины баримлыг зайлуулах, цаашид тэгж мунаглахгүй байх шийдвэр өгөөрэй гэв.

Таль орчуулав.

Фейхтвангер дотор нь онгойн санаа алдав.

-Баярлалаа.

Сталин,

-“Сахалтай хүнийг” тойрсон энэ бүх шуугиан үнэхээр ядаргаатай, бас таны зөв зүйтэй хэлсэнчлэн “болхийг” ч хэлэх үү хэмээн итгэмжлэн өгүүлэв. -Гэхдээ та намайг ч бас ойлгох ёстой. Хүмүүс ингэж хөлсөхдөө гэнэн цайлган сэтгэлээр баясан баярладгийг би мэдэх учраас хүлцэн тэвчихээс өөр арга байхгүй. Нэмэрт нь, энэ бүх магтаал сайшаал чинь биечлэн надад биш, манай оронд социализм байгуулах үйл хэргийг толгойлж байгаа намд маань хамаарч байгаа юм. Чингэхэд манай ард түмэн социализм байгуулах үйл хэрэгт эцсээ хүртэл чин үнэнч шүү.

Тэрээр гэнэтхэн чимээгүй болж, зовхио буулгав. Тэгснээ нүдээ нээж, Фейхтвангерийг хараад инээмсэглэв.

-Та бид зөвхөн манай ажил явдлыг л яриад байна. Гэтэл та зөндөө юм үзнэ, ханатлаа харна, өчнөөн төчнөөн юм мэдэж авна. Та бол зохиолч, чөлөөт мэргэжлийн хүн, даян дэлхийн хаагуур ч явж чадна, харин нөхөр Таль бид хоёр бол албан хаагчид, энэ сандал дээр сууж байгаагийнхаа төлөө цалин авдаг улс. Тэгээд орчлон дээр юу болж байгааг сониноос л мэдэж авна. Энэ бол дэндүү чамлалттай. Тийм учраас хилийн чанадаас ирсэн хүн болгон руу хошуураад дайрчихдаг юм гээд Сталин Фейхтвангер руу хоёр гараа дэлгэн инээж, -Эрхэм минь, нарт хорвоо дээр юу юу болж байна, ярьж өгөөч? гэв.

Тэрээр хоёр гараа ширээн дээр тавьж, эелдэгхэн инээмсэглэн Фейхтвангерийг харав.

Таль Сталины өөриймсөг дотно аясыг яг дүйлгэн уламжлахын тулд үгээ нухацтай сонгон бас инээмсэглэн байж орчуулах явцад Фейхтвангер ойшоон ойлгож буй янзтай толгой дохиж суугааг Сталин хараад, энэ хүн одоо түүний хүн болжээ, шүүх хуралд очих юм байна, тэгээд

зөв бичих юм байна гэдгийг тов тодхон мэдэрчээ.

-Өрнөдийнхний амьсгалж буй агаар бол хэрэглэчихсэн бохир агаар хэмээн Фейхтвангер эхлэв. -Өрнөдийн соёл иргэншилд цог золбоо, хийморь лундааны аль нь ч алга. Нөмрөн айсуу хэрцгий дэглэмийн эсрэг нудрага зангидах нь битгий хэл, хатуухан үг ч хэлж чадахгүй байна. Тэндхийн хариуцлагатай хүмүүс фашизмын эсрэг үг хэлэхдээ бал бурмаар нялууртал нь амталж, мянган тайлбар тавьсан юм ярьж байна. Фашистууд Испанийн бүгд найрамдах улс руу довтолсны эсрэг хариуцлагатай хүмүүс яаж хоёр нүүр гаргаж, яаж хулчгар царайлж байгааг харахад огидос хүрмээр байна.

-Тийм шүү, Герман Итали хоёрын Испани руу хийсэн дайралт бол улайм цайм жудаггүй түрэмгийлэл хэмээн Сталин санал нийлэв. -Даян дэлхийн бүх дэвшилт хүн түүнийг эсэргүүцэх ёстой. Зөвлөлтийн хөдөлмөрчид Испанид бололцоотой бүхий л тусламж үзүүлж байгаа, хойшид ч үзүүлэх болно. Испанийг фашист харгис хүчний дарлалаас чөлөөлөх явдал бол испанчуудын хувийн хэрэг биш, энэ бол бүх тэргүүний дэвшилтэт хүн төрөлхтний нийтийн үйлс мөн.

Тэрээр хэсэг дуугүй болсноо,

-Фашизм бол хүн төрөлхтний заналт дайсан, түүнийг зогсоох ёстой. Бид, манайх, фашизмд зам тавьж өгөхгүй. Фашизмын төлөө-лөгчдийг манайх хор хөнөөлгүй болгоно. Дэлхийн бүх дэвшилтэт хүн үүнийг ойлгож үнэлэх ёстой гэж нухацтай хэлэв.

Яриа гурван цаг үргэлжлэв. Поскребышев зочныг оруулж ирэхэд Сталин цаг харсан юмсанж. Одоо дуусгах хэрэгтэй.

Фейхтвангер дахиад нэг юм хэлснийг Таль орчуулав.

-Ноён Фейхтвангер тантай зургаа аваруулах зөвшөөрөл хүсч байна.

Сталин Поскребышевыг дуудаж, зурагчин ирүүлэхийг тушаав.

Зурагчин орж ирж аппаратаа байрлуулав.

Сталин хананы тэндэх сандал руу очиж суугаад, Фейхтвангерийг зөв талдаа, Талийг солгой талдаа урьж суулгав. Тэр гурав ийнхүү царсан хавтангийн дэвсгэр дээр зургаа авахуулжээ.

Сталин босох зуур,

-За хараа биз дээ, танаас болж одоо сахалтай хүний бас нэг зураг бий болно хэмээн долоовор хуруугаараа занган инээмсэглэв.

Таль орчуулж өгөв.

Фейхтвангер хоёр гараа алдлан дэлгэж инээд алдав:

-Та бол дэлхийн хамгийн сайн, хамгийн амгалан мэтгэлцэгч.

Чин санаанаасаа хэлсэн нь тэр.

Сталин Фейхтвангертэй үүд рүү цуг очоод, өөрөө хаалгаа нээж өгч зочноо гаргав. Таль араас нь гарлаа.

Поскребышев үүдний өрөөний хаалгыг онгойлгов. Фейхтвангер эргэж харлаа. Сталин гараа өргөн үдэв. Фейхтвангер хариуд нь талархан инээмсэглэж, толгой дохив. түүний араас хаалга хаагдлаа.

Сталин өрөө рүүгээ орох замд Поскребышевийн дэргэд зогтусав.

-Зохиолчийг над руу шууд оруулаарай гэж би танд орос хэлээр хэлсэн. Та яагаад шийдвэр биелүүлсэнгүй вэ?

Поскребышев айгаад тийм шийдвэр аваагүй гэж бас л хэлж чад-сангүй. Сталин тэр зохиолчид хямсгар түшмэл биш, орж гарахад төвөггүй хүн гэдгээ харуулах гэж бодсон байх, гэхдээ тийм шийдвэр өгөөгүй. Өгнө гэж бодож байгаад мартчихсан бололтой. Поскребы-шев урьдчилж илтгэлгүй хэн нэгнийг оруулж зүрхэлсэнгүй.

-Нөхөр Сталин, уучлаарай, аяндаа л тийм болчихож хэмээн Поскребышев гэмшин өгүүлэв.

-Таль, Ставский хоёрт ингэж дамжуул: Энэ германд бүх нөхцө-лийг бүрдүүлж өг. Шүүн таслах ажиллагаа хүртэл юу хүссэнийг нь хэвлүүл. Шүүн таслах ажиллагааны тухай бичсэн юмыг надад эхлээд үзүүл.

Сталин үүдээ хааж, өрөөн дотуураа хэд алхсанаа цонхны дэргэд очиж зогсов.

Кремлийн барилгуудын дээвэр дээр цас тогтжээ. Зэвсгийн ордны гадуур эгнүүлэн тавьсан зэс үхэр буунууд дээр ч цас тогтчихож.

Тэрээр Фейхтвангертэй өөрийнхөө хийх юмыг хийлээ. Одоо Таль, Ставский, Вышинский, Радек энэ тэр гүйцээж хийг. Фейхтван-гер хүнд л итгэдэг юм бол Радект итгэж таарна. Хоюулаа еврей, сэтгүүлчид, сэхээтнүүд юм чинь. Радек шүүх хурал дээр ч гэсэн хурц ухаан, өргөн мэдлэгээ гайхуулж, өөр рүүгээ анхаарал татахыг хичээнэ. Өөрийгөө Германаар мэргэшсэн хүн гэж үздэг хүн, бүр 1919 онд, бас 1921 онд германуудтай хэлэлцээ хийж байсан. Гэхдээ энэ тухай тэр ярих шаардлагагүй, тэр үед Орос, Герман хоёр шал өөр харилцаатай байсан. Харин Гитлерийн итгэмжит хүмүүстэй хийсэн с ү ү л ч и й н х э э яриа хэлэлцээний тухай л шүүх хурал дээр яриг. Юу ч зохиож ярих шаардлага гарахгүй, хүмүүсийн нэр усыг нэрлээд үнэнийг л хэлэг. Ганцхан шаардлага байгаа: Троцкийн даалгавраар, түүний нэрийн өмнөөс яриа хэлэлцээ хийсэн гэж хэлэх ёстой. Тэгвэл Фейхтвангер тэр мэдүүлгийг орчлонгоор нэг тараагаад өгөхөө мэднэ... Зохиолч! Дэлхийд зартай хүн! Антифашист уу? Мөн, гэхдээ коммунист биш, тэр ч байтугай антикоммунист.

Тэрээр энэ болон дараа дараачийн шүүн таслах ажиллагааны тухай албадаж байгаад даян дэлхийд итгүүлнэ. Тэгвэл урьд өмнө болсныг бас итгүүлсэн хэрэг болно. Тэрээр энэ шүүх хуралд Фейхтвангерийг төдийгүй, гадаадын дипломатууд, сэтгүүлчид гээд дуртай

ажиглагчдыг оруулна. Орцгоо! Тэд бүхэн түр зуурын холбоотнууд гэдэг нь мэдээж. Гитлер тэр хоёрыг сөргөлдөж байгаа цагт тэд нар холбоотон. Тэд нар зөвхөн шийдвэрлэх эргүүлэг хүртэл л холбоотон. Харин тэр үед бол цаг үе ч өөр болно, дуулах дуу ч өөр болно.

Пятаков-Радекийг шүүн таслах ажиллагаа гайгүй болж өнгөрөв. Шүүгдсэн арван долоон хүн бүгдээрээ аймшигт гэмт хэргээ хүлээцгээжээ. Арван гуравт нь алах ял, дөрөвт нь шоронд хорих ял зааж, тэр дөрвөөс Радек, Сокольников хоёр хожим шоронгийнхоо өрөөнд алагджээ.

Фейхтвангер Өрнөддөө буцаж очсоны дараа, Амстердам хотноо “Москва. 1937” гэдэг ном хэвлүүлжээ.

Фейхтвангер ингэж бичиж байна:

“Сталин бол суу билигтний өндөрлөгт хүрсэн оросын ажилчин, тариачны төлөөлөгч... Сталин ард түмэнтэйгээ яс махны холбоотой, ажилчин тариачинтай тэр хүн холбоогоо хадгалж үлдсэн... Ард түмний хэлээр ярина. Үнэхээр илэн далангүй яриатай, төлөв даруу, өөртөө ямар ч цол хэргэм олгоогүй, хүн нэг бүрийн заяа тавиланд санаа тавина, төрсөн өдрөө нийтийн баяр болгон тэмдэглэхийг зөвшөөрөөгүй, ажилчин, тариачныхаа хэрэгцээ шаардлагыг өөрийнх шигээ мэднэ, өөрөө тэдний нэг... Зөвлөлт Холбоот Улсыг шинэ ардчилсан Үндсэн хуультай болгосон, үндэстний төвөгтэй асуудлыг нэгмөсөн зохицуулсан...

Зөвлөлтийн иргэдэд элбэг дэлбэг хоол хүнс, хувцас хунар, кино, театр байна. Арван жилийн дараа тэд нар ямар л бол ямар чанар-тай, хичнээн бол хичнээн орон сууцтай болно... Тэд нар жагсана гэхээрээ хүүхэд шиг баярлан гүйлдэнэ... Зөвлөлт Холбоот Улсад эрдэмтэд, зохиолчид, зураачид, жүжигчид сайн амьдарч болж байна... Төрөөс тэднийг хүндлэн дээдлэж, өндөр цалингаар тэтгэн ивээж байна... Жанжин шугамнаас хазайсан зохиолчдыг дарамтлах-гүй байна... Зөвлөлтийн сонинууд миний өгүүллүүдийг хянаж танаж элдэвлээгүй. Ойрын ирээдүйд Зөвлөлт Холбоот Улс дэлхийд хамгийн аз жаргалтай, хамгийн хүчирхэг орон болно...”

Бас ингэж бичиж байна:

“Би шүүн таслах ажиллагаан дээр байлцаж Пятаков, Радек хоёрыг сонссон, хэрвээ энэ бүхэн зохиомол буюу найруулсан зүйл юм бол би үнэн гэж юу байдгийг мэдэхгүй... Сталины ямар ч номыг, ямар ч хэлсэн үгийг уншихад л, түүний ямар ч хөргийг харахад л энэ ухаантай, хэрсүү бодлоготой хүн тоо томшгүй олон хүний тус-лалцаатай тийм бүдүүлэг инээдмийн жүжиг тавих мэтийн аймшигт мунхаг ажил хийхгүй нь нэн даруй тодорхой болно”.

Зөвлөлт Холбоот Улсад уг номыг нүд ирмэхийн зуур орчуулж нийтлэсэн: 1937 оны арван нэгдүгээр сарын 23-нд үйлдвэрлэлд өгч, 24-нд хэвлэлтэд шилжүүлж, тэр даруй 200 000 хувь хэвлэжээ. ЗХУ-д хуучин хэвлэгдсэн Фейхтвангерийн романууд дээр төдөлгүй түүний “Хуурамч Нерон”, “Иудейн дайн”, “Цөллөг” зэрэг роман шинээр хэвлэгдэв. Тэрээр ЗХУ-д хүндтэй, нэртэй зохиолч болж, түүнийг “их хүмүүнч” хэмээн зөндөөн их бахдан бичдэг болсон байна.

Галт тэрэгний буудлын жижгэвгэр модон байшинд томчуул, багачуул холилдон чихжээ. Саша оочерийн төгсгөлийг олох гэж цөхрөнгөө барав. Чемодан нь хөнгөхөн ч гэсэн тээр болоод болдоггүй, ядахаар тавьчих газар ч алга. Үүргэвчний давуу талыг мань хүн чухамхүү энэ Тайшетын буудал дээр л ойлгож үнэлэв. Хоёр гар сул, хүч л байдаг юм бол амьтны дундуур зүтгэлж байхад хичнээн амар байхав. Гэвч эндшээ хүн битүү чигжээтэй учраас баргийн хүч нэмэр болохгүй л дээ.

Буудлын талбай дээр зоолттой цагаан хоолой байдгаараа орилно. Хаалга байнга онголзуулахын зэрэгцээ гишгүүр нь цас овоорч хөлдөөд олигтой хаагдахгүй учир радиогоор зөвлөлтийн эсрэг троцкист төвийг шүүн тасласан тухай нэвтрүүлж буй нь тод сонсдож байв.

Саша энэ шинэ шүүх ажиллагааны тухай огт дуулаагүй болохоор сонсонгуут хачин оргиод явчихав. Нам, улсын томоохон удирдагч Пятаков, Радек, Сокольников, Серебряков, Муралов энэ тэрийг алуурчин, тагнуул, хорлон сүйтгэгч гэж нэрлэж байлаа. Энэ шүүх хурал хэзээ эхэлсэн байх вэ? мань хүнийг Тайшет орж явах хооронд уу?

“Гадаадын тагнуулын албаны төлөөний этгээдүүдтэй хамтран хорлон сүйтгэх ажиллагаа явуулж, галт тэрэг онхолдуулах, уурхай, үйлдвэрийн газрыг галдан шатаах, дэлбэлэх ажлыг зохион байгуу-лахдаа эдгээр яллагдагсад ажилчдыг хүнсээр хордуулан алах зэрэг аймшигт ялт хэргийг ухамсартай бодож боловсруулан үйлдэж, тэмцлийн ямар ч шившигт муухай аргыг цээрлэхгүй байжээ.

Яллагдагсад тэдэнд тулгасан ялыг бүгдээрээ бүрэн хүлээсэн байна”.

Саша сонин олж уншмаар, үгүйдээн талбай руу гарч нэвтрүүлгийг үг бүрчлэн сонсмоор санагдавч, хэний ард зогсохоо мэдэж авалгүй яаж гарахсан билээ?

Яваандаа Саша зүгширч, юмны баримжаатай болов... Нэг багав-тар оочер нь ердийн ардынх юм байж, хамгийн горьдлогогүй оочер, мань хүн тийшээ зогслоо. түүнээс хавьгүй урт оочер нь томилол-тынхных юм байж, гэтэл тэдний урдуур ДЯАК-ын тээврийн хэлтсийн захиалгат суудалтай хүмүүс орох эрхтэй гэнэ. Ер нь дампуу юм болох нь, Тайшетаас явж чадах уу, үгүй юү, бүү мэд.

Тасалбар түгээврийн цонх галт тэрэг ирэхээс арван таван минутын өмнө онгойно, тэгвээс томилолтынхны оочер бужигнаж өгнө. Учир юун гэвээс, бүх тасалбарыг зөвхөн Эрхүү хүртэл өгнө, Красноярск хүрэх хүн Эрхүүгийнхнийг урдуураа оруулах ёстой. Гэтэл хүн болгон оочероо алдах, шахагдаж гарахаас айж, бөөн дуу шуугиан болно. Ердийн оочерт бол тийм юм огт алга, хэнд ч тусгай эрх байхгүй, хэн ч элдвийг эс шаардана.

Галт тэрэг хэдхэн минут зогсдог болохоор тасалбар авсан хүмүүс чемодан, цүнхээ шүүрэн буудлын тавцан руу ум хумгүй харайлгана.

Саша ямар галт тэрэг Тайшетаар дайрч өнгөрдгийг мэдэж авах, гол нь радио сонсох санаатай буудлын тавцан руу бас гарлаа. Бүгдийг нь сонсохгүй ч гэсэн юун шүүн таслах ажиллагаа явж

буйг хэсэгчилж ч атугай мэдэх хэрэгтэй биз дээ.

Яллагдагч Радек мэдүүлэгтээ 1935 оны арван хоёрдугаар сард Троцкийгээс хүлээж авсан удирдамжийн захидлыг ишлэн дурдаж байна:

“... Нэн чухал хөрөнгөтний засгийн газрууд, ялангуяа өнөөгийн Герман, Японых шиг ихээхэн түрэмгий засгийн газрын нааштай хандлагагүйгээр засгийн эрхэнд орж болох мэт бодох шиг утга учиргүй юм байхгүй. Бүр одоо эдгээр засгийн газартай холбоо сүлбээтэй, тохиролцоотой болох зайлшгүй шаардлагатай... Арга буюу газар нутгийн буулт хийх хэрэгтэй болно... Японд Приморье, Амар мөрний орчмыг, Германд Украиныг өгөх хэрэгтэй болно...”

Өнгөрсөн наймдугаар сард Радек сониноор дамжуулан, Зиновьев, Каменев хоёр гэм буруугаа “толгойгоороо хариуцах” ёстой гэж шаардаж байхад түүний халаасанд Троцкийн захиа аль хэдийн орчихсон байсан болох нь уу? Хоёр нүүр гаргаж байсан байх нь уу?

Саша буудалд буцаж ороод чемоданаа дэргэд нь үлдээсэн нэг ац малгайтай өвгөнийг нүдээрээ хайж олтол түүн дээр хоёр эргүүл ирчихсэн ямар нэг юм шалгааж байгаа янзтай харагдав. Арай мань Сашагийн чемоданыг хэний юм бэ, эзэн нь хаана байна вэ? гэхчилэн асууж байгаа юм биш биз?.. Үгүй ээ, үгүй бололтой, тэгвэл өвгөн юу гэж өөрийнхөө паспортыг үзүүлж байхав. Нөгөө эргүүлүүд оочерийн хажуугаар урагшилж, хоёр залууг татаж гаргаад бас бичиг цаасыг нь үзэв.

Саша эргүүлийнхнийг далд ортол хүлээж байгаад өвгөн рүү чихэлдэн очиж,

-Тэд нар юу гэнэв, таны баримт бичгийг шалгаа юу? гэж болгоомжтой асуув.

-Гуравдах удаагаа паспорт үзэж байна. Сая амралтаа авсан тухай нотолгоо шаардлаа. хэн тийм нотолгоо өгдөгсөн билээ дээ? хэн ч өгөхгүй.

Өвгөн анх Сашад харагдсанаасаа арай залуу ажээ. Хориход байдаг авгайгаа эргэсэн юм байж. Тэд Харьковынх гэнэ, өөрөө эм найруулагч, эхнэр нь сувилагч.

-Тэр хоёр залуугаас паспорт биш, ямар нэг цаас үзнэ билээ.

-Тэгвэл цахилгаан биз. Оршуулга, хурим энэ тэр гээд аль явдлыг тэр гэхэв... Бас л шалгуулах ёстой.

-Бүх хүний бичиг баримтыг үздэг юм уу?

-Бичиг баримт... Энд хүн болгоныг рентгенээр харж байгаа юм шиг шалгана шүү.

За ийм байдаг байх нь. Саша гадагш гараагүй, эндээ байж байсан бол шууд өртөх байж! Ямар нэг юм бодож олохгүй бол горьгүй нь.

Зарим нэг санаа толгойд орж, Саша юу хариулахаа бэлтгэж амжсан ч гэсэн эргүүлийн хоёрыг ойртохын үес дотор палхийх шиг болов. Паспортад нь “Ялын хугацаа дууссан тухай гэрчилгээг үндэслэн олгов” гэж бичээтэй буй нь ямар гай тарьж болохыг Тэрээр ойлголгүй

яахав.

Нэг нь цаасыг эргүүлж уншсанаа нөгөөдөхийгөө дуудаж, тэгээд

хоюулаа Сашагийн паспортыг эргүүлж тойруулж харцгаав. Цөллөгнөөс яваа хүн нэвтрэх бичгийн оронд шууд паспорттой байхыг анх удаа үзэж байгаа бололтой. Ийм байж болох уу? Ийм байх ёсгүй! Хорихоос яваа хүнд хаа хүрэх, хаана оршин суухыг нь заасан нэвтрэх гэрчилгээ байх ёстой. Тэр газраа очоод паспорт авч, зохих байгууллагын бүртгэл дансанд орох ёстой. Энэ нэг л биш ээ!

Ингэж гэмээ нь энэ эргүүлийн дүлий годилуудад мань хүн юу ч нотлож чадахгүй. Эд нар паспортыг нь буцааж өгөхгүй байсан ч чадна. Комендантын газар аваачаад, ийм нэгэн этгээдийг яах вэ гэж Красноярскаас асуулгана. Юуны чинь яах вэ гэж? Гар дор чинь шорон байж байна, тийш нь хийчих, тэгээд учрыг нь олъё гэж хариулна... Тэгээд мужийн “гурвын” шийдвэрээр мань хүнд х у у ч и н х э р г и й н х н ь төлөө ш и н э я л ы н х у г а ц а а наачихна. Одоо тэд нар ял эдэлсэн хэргийнх нь төлөө дахиад ял заачихдаг аргатай болчихоод байгаа юм.

-Хаашаа явж байна?

-Канск руу явж байгаа ухаантай хэмээн Саша Сибирь маягаар хариулав.

-Яах гэж явж байна?

-Хадам эхдээ очихоор.

-Хадам эх чинь хаана суудаг юм бэ, хаяг нь?

Саша, яагаад ч юм бэ, Соловейчикийн нэгэнтээ сууж байсан гудамж, байрны хаягийг тогтоосон байснаа хэлж орхив.

-Тэгвэл тэнд хэн байна?

-Тэнд гэж аньд?

-Ойлгохгүй байна уу? Кежмад хэн байна?

-Ухаан нь, авгай, хүү... Бүгд тэнд байгаа.

Эргүүл Сашагийн паспортыг эргүүлж тойруулсаар байснаа түүн рүү эгцлэн харав.

Саша зүрх нь амаараа гарах шахаж байвч, тайван байхгүй бол яаж ч мэдэх юм чинь, эргүүлийн өөдөөс ч хэнэггүй мэт харж зогсов. түүнийг буруутгах юм байхгүй. Хугацаагаа дуусгаад авгай хүүхэдтэйгээ Кежмад суурьшсан, одоо энүүхэн зуур Канск руу хадам эх рүүгээ явж байна. Юу нь болохгүй билээ? хэн ч ухааж төнхөөд юм олохгүй. Энэндээ мань хүн өөрөө бараг итгэчихэж.

-Хадам эх рүүгээ явж байгаа болох нь уу?

-Тийм.

-Хадамдаа айлчилж, найраа гүйцээх нь...

-Айлчлах биш, Кежмад авчрах гэж явна. Нас дээр гарсан хүн. Эргүүл дахин сүржин дүрийг олж, Сашаг сонжин харав. Саша хэнэггүй царайлавч, аваад явах нь уу, орхих нь уу хэмээн дотроо эрэгцүүлэн байв. Орхих юм болов уу?.. Кежмад суудаг юм чинь, тэнд хэсгийн төлөөлөгч байгаа, тэд түүнийг хариуцах ёстой. Тэд нар л хариуцаг! Ингэж бодож болно оо доо.

Саша таасан эсэхийг бүү мэд, эргүүл ямар ч атугай, паспортыг нь нугалж буцааж өгөөд, нөгөөдөхийгөө дагуулан хананы тэрүүгээр зогсож байгаа, богц, чемодан энэ тэр дээрээ, эсвэл бүр шууд шалан дээр сууж байгаа хүмүүсийн бичиг баримтыг шалгасаар цаашлав.

Саша эргүүлийн араас хараа салгаж чадахгүй, байрандаа хөшсөн мэт нэг хэсэг зогсов.

Талбай дээр радио хангинан байвч, мань хүн чих нь дүнгэнээд олигтой сонсогдох юм алга, тэгээд ч сэтгэл нь ер уужирч өгдөггүй, санаа бодол ч төвлөрөх янзгүй, гагцхүү “дайн” гэдэг үг давтагдаад буйг мэдрэв:

“... Шүүгдэгч Пятаков Кемеровогийн химийн комбинатыг дайн эхлэнгүүт галдан шатаахаар бэлтгэхийг шүүгдэгч Норкинд тушаал болгожээ.

Пятаков нотлон хүлээсэн.

-Тийм, би Норкинд үнэхээр тийм даалгавар өгсөн...”

Нэвтрүүлэгч одоо Князев гэдэг нэр хэлж байна:

“...Цэргийн ангиуд руу явуулж байгаа галт тэрэгний цуваа, түүнчлэн цэргийн хоолны газар, ариун цэврийн газруудыг хурц халдварт нянгаар халдварлуулах зорилгоор дайн эхлэмэгц бактериологийн зэвсэг хэрэглэх тухай асуудлыг Японы тагнуулын албанаас онцгойлон тулгаж байсан...”

Буудлын чийдэн тортогтон сүүтийж, тамхины бохь, хүний хөлс, бас бус эхүүн үнэр холилдон ханхлана. Саша чемоданыхаа хажууд хана налан түр суузнав.

Вьшинский Радекаас ЗСБНХУ-ыг ялуулахын төлөө байсан уу, ялагдуулахын төлөө байсан уу гэж асуухад цаадах нь өчүүхэн ч түгдрэхгүй хариулж байв:

“... Би ялагдуулах гэж туслаж байсан”.

Энэ шүүн таслах ажиллагаа, энэ өөрийгөө илчилсэн улайлтууд Сашагийн сэтгэлийг их зовоож байв. Тэрээр троцкистуудын хүлээн гэмшээд байгаа гэмт хэрэгт ямар ч холбогдолгүй. Гэхдээ мань Панкратов тэр хэрэгт холбогдолтой эсэхийг хэн шүүн тунгаах юм бэ? 58 дугаар

зүйлээр яллагдсан уу? Яллагдсан. Хувьсгалын эсэргүү гэж үзсэн үү? Үзсэн. Тэгэхээр, мань хүн тэр дайсагнагч талынх гэсэн үг, энэ бол түүнийг дахиад хэрэгт татахад хангалттай. Бушуухан эндээс холдож, хүний паспортыг өдөрт хэдэнтээ шалгаад байдаггүй ямар нэг нүх рүү шургаад орчих юмсан.

Томилолтын бус хүнд тасалбар олдохгүй байгаа ч оочер бага багаар хорогдсоор байна. Яагаад, юуны учир ингэж буйг Саша эс ойлгоно. Нөгөө авгайгаа эргэсэн ац малгайтай өвгөн гэнэтхэн алга болчихож. Ачаа бараа байхгүй, хоосон шахуу ганц үүргэвчтэй юм чинь, аль нэг галт тэрэг рүү явдал дунд нь үсрээд орчихсон юм болов уу?

Бусад нь гарч орно уу л гэхээс биш, оочерийнхон бүгдээрээ байх шиг, хэний ард байгаагаа дор бүрдээ мэднэ. Саша ч бас гарч, жижигхэн хүнсний зах дээрээс сүү, талх авсан. Сүү нь хөлдүү учраас сэнжтэй аяга худалдаж авахаас өөр аргагүй болсон. Буудлын байранд сүү нь аяндаа гэсч, талхаа даруулж уухад тун дажгүй, жаахан л болохоос амт гэж хачин сайхан.

Саша дугуй дугуй хөлдөөсөн сүүг хараад Мозговаг санах. Хоёр хөгшин мань хүнийг Москвад хүрч яваа гэж бодож байгаа байлгүй. Эзэгтэй түүнд замын хүнс төхөөрөх гэж, Лукичийг гахайн жирээ, давсалсан загас авчруулахаар зорь руугаа хөөгөөд байсан. Саша гал зуух руу орж, Лукичийн ширээн дээр авчирч овоолсон юмыг хараад, “Пээ, бүтэн чарганы ачаа бэлдчихэж!” хэмээн инээд алдсан. Суллагдана гэхээс юуг ч тоохгүй, хөл газар хүрэхгүй байсан цаг. Юухан хээхэн халаасандаа хийж, гахайн жирээг чемодан руугаа шургуулаад,

-Тайшет хүрчихвэл бол оо, тэнд очингуут галт тэргэнд суучихна хэмээн бусдыг нь орхисон.

Тэрээр эрх чөлөөт амьдралаа ингэж төсөөлж байсан билээ.

Өлөн зэлмэн, сахал үс нь өрвийсөн, - сахал хусах газар ч алга, ер нь ч хусахтай мантай - хоёр нүд нь улайсан мань Саша шалан дээр суугаад, өвөр дээрээ чемоданаа тавьж, дээр нь гараа зөрүүлэн дэрлээд унтав. Ууц нуруу, хоёр хөл энэ тэр нь чилээд нойр биш там гэлтэй. Суудлын, ачааны гэхчилэн янз бүрийн галт тэрэг ирж явсаар байна.

Владивостокийн суудлын буухиа галт тэрэг ирээд явлаа. Гэрэл гэгээ гялбуулсан, цонх нь цагаан хөшигтэй цоо шинэхэн вагонууд, уурын тэрэгний яг ард торлосон цонхтой шуудангийн вагон байна, Москва руу захидал авч яваа гэсэн үг.

Тэгтэл Москвагаас зөвхөн түрүү адаг хоёртоо суудлын вагон зүүсэн ачааны галт тэрэг ирж, буудлын хаяа руу, тавцангүй зам дээр зогсов. Суудлын вагоноос хянагчид гарч ачааны вагоны гадуур эгнэн зогсоцгоов... Ингээд Саша ачааны вагоноос хоригдлуудыг яаж буулгадгийг анх удаагаа харлаа.

Гүйдэг хаалгыг нь дутуу онгойлгов. Харгалзагч нэг хүний овгийг хашгирахад хоригдол хаалга руу ирж, хослоо нэр, төрсөн он, ялын хугацаагаа өндөр дуугаар илтгэнэ. Харгалзагч жагсаалттай тулгаж үзээд “бол оо!” гэхүйд сайхь хоригдол уут юм уу, чемодантайгаа вагоноос үсэрч бууна. Насаар арай залуу нь ингэж үсрэнэ, ахимаг насныхан нь өндрөөс бэргэн, дотогшоо харж гэдсээрээ зүүгдэхийж байгаад цасан дээр ойчиж, тэр чигээрээ босолгүй, өвдөг сөхрөн жагсана. Тэгээд дараачийн хүнийг дуудахад тэр нь үсэрч буух буюу өнхөрч

ойчно. Вагоны хүн дуусан дуустал ийнхүү үргэлжлэнэ.

Ачааны вагонуудын тэн хагасаас хоригдлуудыг буулгав. Юухан хээхнээ үүрсэн буюу барьсан эрэгтэй, эмэгтэй хоригдлууд сөхрөн

жагссан нь даан ч арчаагүй харагдана.

Хараал зүхэл тавин, өшигчиж түншчин байж хоригдлуудыг босгож жагсаав. Тэгээд хоёр зуугаад метр алхуулснаа цасан дотор дахиад өвдгөөр нь суулгав. Тэнд нь хорихын юм уу, цөллөгийн газрын харгалзагч хүлээж байгаа юм байж. Дахиад дуудлага: Овог нэр, төрсөн он, ялын хугацаа... Нэг харгалзагч нөгөөдөө хоригдлоо хүлээлгэж өгч байгаа нь энэ. Алслан холдох орилоон хашгираан, хараал зүхэл, нохдын хуцаан уурын тэрэгний дохио, өнгөрч буй ачааны галт тэрэгний хяхтнаан нүргээнтэй холилдон замхрана.

Саша өөрийг нь ийм л тавилан хүлээж байгаа гэхээс жихүүдэс хөдлөж, захаа босгов. мань хүнийг суллаж тавьсан нь алдаа. ДЯАК ийм алдааг дор нь засдаг юм чинь.

Муухай юм харж дотор харласан Саша буудлын зүг сажлав. Талбай дээрх чанга яригчийн тэнд хүмүүс бөөгнөрөн, Вышинскийн Арнольд гэгчийг байцааж байгааг сонсоцгоож байна. Арнольд гэж хэн болох тухай Сашад ямар ч ойлголт байсангүй, гэхдээ яваандаа хэлж магадгүй...

“Вышинский: Яллагдагч Арнольд, таны жинхэнэ овог хэн бэ?

Арнольд: Васильев.

Вышинский: Тэгвэл хослоо нэр чинь?

Арнольд: Валентин Васильевич.

Вышинский: Алан хядах үйлдэл хэзээ, хэний эсрэг зохион байгуулж байсан бэ?

Арнольд: ... Би машинаа орц руу тулгаж зогсоход Молотов машинд орж суусан. Шороон замаас гарч засмал руу орох гэтэл өөдөөс нэг машин гэнэтхэн нисэх мэт дүүлж явна. Тэгмэгц юун бодох модохтой мантай, би алан хядах үйлдэл хийх ёстой болсон... Гэтэл би айчихсан юм. Тэгээд замын хажуугийн гуу руу зайлж амжсан...

Вышинский: Та юунаас болж зайлсан бэ?

Арнольд: Би хулчгараасаа болж зайлсан”.

Нэг хөдвөр эр хажууд нь ирж зогсоод, өлийн байж чагнав. Үүдэн шүд нь цөмөрхий, нүдэнд хүйтэн энэ этгээд Сашатай энэ талбай дээр хэд хэд таарч байгаа юм.

-Эргэн тойрон дандаа тагнуул, икээ нь яаж байсан, засгийн газрыг ална гэнэ, муусайн хараал идмэрүүд... Биднүүсийг өнчрүүлэх гэж...

“Г” үсгийг хөндий дуудаж байна. Украинных уу, эсвэл Кубаных уу гэж Саша бодов. Яаж яваад энд ирчихэв? Юу гэж яриа өдөөд байна? Санамсаргүй ингэж байна уу? Алтан хошуу өргөгч үү?

-Урусыг их янчаанаас германчинд бас япончинд зарах санаатай гэнэ, оросын ард түмнийг онигор нүдтэний өмнө бөхөлзүүлэх юм гэнэ...

“Урусыг их янчаанаас зарах нь” гэж энэ хүний толгойд бууж

байгаа юм байна.

-Хөөе, залуу, Урус маань ямар үнэтэй байж болох вэ? Чи юу гэж бодож байна? хэмээн нөгөө эр салах царай алга.

-Чи яах нь вэ? Оросыг өөрөө зарах гээ юү? Аль вэ, эндээс зайл! гэж Саша уурлав.

Нина сургууль дээрээ өнжинө, Варя өдөр нь ажилтай, орой хичээлтэй болохоор тэр хоёр уулзаж таарах нь тун ховор. Гэвч яриа хөөрөөгүй цуг аж төрнө гэдэг тэсэх юм биш. Варя радиогоор сонссон болгоноороо Нинаг дооглож байгаа нь нүүрэн дээр нь илт, бас “энэ бүхэнд” итгэдэг гэж үзэн ядаж байгаа нь ч илт. Варя яаж ч мэднэ. Ингэсээр байгаад ер нь юу л болдог бол доо?!

Тэдний орцноос нэг “ардын дайсныг” баривчилжээ. Тэр нь энд ердөө гурван сар суусан хүн, гэтэл цуг сууж байсан Дима Полянскийг сонор сэрэмж алдсан хэргээр намаас хөөжээ. Нина тэр хоёр бүр хүүхэд ахуй цагаасаа үерхсэн хоёр. Тэр үес мань хоёр шатан дээр нэг удаа тааралдсан чинь Дима түүний тохойноос барьж байгаад, чихэнд нь “Би түүнтэй “сайн байна уу?”, “баяртай”-гаас өөр хоёр үг ч хүний урманд сольж үзээгүй, гэтэл районы намын хорооныхон сонсохыг ч хүсээгүй, шууд л хөөчихсөн, тэгээд л гүйцээ” гэж шивэгнэхэд нь, Нина хариуд нь,

- Одоо чинь ноцтой цаг үе, онцгой сонор сэрэмжтэй байх шаардлагатай хэмээн хөмсөг зангиджээ.

Дима түүнээс ухартуссанаа, гурав гурван гишгүүр алгасан гишгэж, дээшээ харайлгасан. Баяртай энэ тэр ч байхгүй. Араас нь “Хонгор минь, миний хайрт дүүгээс болж намайг ч гэсэн өнөө маргаашгүй хөөж мэднэ” гэж хашгирмаар санагдсан. Мэдээж, юу гэж тэгж хашгирах вэ, гэхдээ урам алдарч, хаалгандаа түлхүүрээ хийхэд гар нь салганаж асан.

Диматай шал дэмий бүдүүлэг харьцлаа, тусгүй юм боллоо. Өөрөөс нь хоёрхон ах ёстой сайн залуу. Нисэхийн салбарт ажилладаг инженер. Уржнан агаарын флотын баяраар Нинаг Тушинод урьж аваачсан. Нина дуртай очсон, дараа нь ч харамсаагүй. Сэтгэл эзэмдсэн сайхан юм үзсэн. Нарлаг өдрийн цэлмэг хөх тэнгэрт онгоц шунгинан нисэлдэж, цасан цагаан парашют цэцэг мэт дэлбээлэн, эргэн тойрон хүмүүс хөхин баясаад л. Нисэгч нар ёстой баатарлаг залуус!

Нина тэгэхэд тэднээр бахархаж байсан, эх орноороо бахархаж байсан, одоо ч бахархаж байна.

Дима түүнд нүүр өгч, өөриймсөг хандан утасдаж барина. Мартын наймнаар цэцэгтэй, Майн нэгэн, Октябрийн баяраар хайрцаг чихэртэй ирнэ. Гэхдээ түүний ийнхүү эргүүлэхийг Нина төдийлөн эс ойшооно. Нэг л хүнийрхүү санагдаад байх. Харин Максимтай бол илэн далангүй жаргал зовлонгоо хуваалцана, түүнд хамаг юмаа уудлаад ярьчихаар сэтгэл аяндаа тайвшраад ирнэ.

Максимын захиа ч цаанаа л нэг ухаалаг хэрсүү, цайлган дорвилог. Тэрээр амралтаараа хоёр удаа ирсэн, тэр хоёр үзэсгэлэн, театр цуг үзсэн, өөрөө сонгодог хөгжим ойлгодоггүй, дургүй ч гэсэн Нинагийн дуртайг мэдэх учир консерваторт орох тасалбар яаж ийгээд олсон байсан. Нинад л сайхан байвал бол оо гэсэн шиг концертний эхнээс аваад дуустал нь чимээгүй суучихна. Өөрөө бол ардын дуунд дуртай, ноднин тэр хоёр “Максимын залуу нас”-ыг үзсэн, Максим киноноос буцах замын турш “Цэнхэр бөмбөлөг эргэнхэн эргэлдэнэ, тэргүүн дээгүүр эргэнхэн эргэлдэнэ, эргэн эргэлдсээр унах гээд байна, энэ нэг залуу бүсгүйг хулгайлах гээд

байна” гэж дуулсан. Нина сэтгэл өег байсан учир бас түүнийг даган аялж явсан. Харин Максимын толгойд нэг ая орчихвол түүнээс мөд салахаа үзэхгүй. Гуравдах өдрөө Нина тэсэлгүй “Болиоч ээ, чи өөрөө ч гэсэн залхдаггүй юм уу?!” гэж үглэсэн. Макс тэгэхэд “Би бас нэг бүсгүйг хулгай хийх санаатай, тэр санаандаа дасгаж байгаа ч юм бил үү” хэмээн мөчөөгөө өгөөгүй. Нина хариуд нь “Макс, хүлээ, одоо цаг нь биш” гээд инээмсэглэжээ.

Яагаад одоо биш гэдгийг Нина өөрөө нарийн тайлбарлаж эс чадна. Сургууль, хүүхдүүддээ дассанаас болсон байж магадгүй. Түүхийн багш хүнд номын сан, дамжаа сургалт, музей гээд мэргэжилтэй холбоотой бүх юм Москвад байна. Тэр бөглүү Алс Дорнодод энэ зүгийн юм юу ч байхгүй. Хөдөөний нэгэн янзын амьдралын эрхээр хүүхэд шуухад цуваад эхлэнэ, цэргийнхэн болсон хойно хот сэлгэн нүүгээд эхлэнэ, дуртай ажлынхаа оронд хүүхдийн даавуу угааж, олон нийтийн ажлын оронд ногоотой шөл хийх л үлдэнэ.

Максыг буцсаны дараа Варя нэг удаа түүнд, “Гэрлэх хүн гуай чинь алдуураад явчих вий” гэж хэлсэн. Нина дүрсхийгээд явчихсан. Завхай яриатай балай! “хүн гуай”, “алдуурах” энэ тэр гэнэ шүү. Харин чамайг нөхөртэй болчихоод байхад чинь надаас авахуулаад атаархсан хүн даанч байгаагүй”. Варя хариуд нь, “Гэртээ өтлөдөг хүүхэнд бас хэн ч атаархахгүй” гээд тавлах мэт инээвхийлжээ.

Тэр хоёр иймэрхүү үгээр шидэлцчихээд дараа нь хэдэн долоо хоног хоорондоо дуугарахгүй.

Цаашид ингэж байх арга алга. Хоёр тийшээ болох хэрэгтэй.

Арван нэгдүгээр сарын сүүлчээр, Нинагийн төрсөн өдрөөр Лена Будягина утасдав. Овоо доо, баяр хүргэх нь, юм мартдаггүй, бүх юмаа санаж байдаг сайн хүүхэн шүү. Горькийн гудамжинд байдаг мөхөөлдөсний кафед очиж болно, ойрд уулзаагүй юм чинь жаал ярьж сууцгаахгүй юу. Гэтэл Лена баяр хүргэх гэж утасдаагүй ажээ.

-Нина, аав маань байхгүй болсон.

Нина тэр даруйдаа ойлгосонгүй. Нас бараа юм болов уу? Тэгснээ, Иван Григорьевич баригдсаныг дорхноо ойлгоод,

-Би эргээд утасдья гэж бушуухан өгүүлэв.

Тэгээд утсаа тавьжээ. Айсандаа энэ үү? Үгүй, юу гэж айх билээ? Гэхдээ энэ тухай утсаар ярилтай биш. Тэрээр өрөөндөө эргэж ирээд, сандал дээр лагхийтэл сууж бодолд автав. Лена дээр очих уу, байх уу? Тэдний байрыг ажиглаж байгаа. Тэр тодорхой. Зөвлөлүүдийн 5 дугаар байшингаас өдөр болгон хэн нэгнийг баривчилж байгаа нь сонинд нийтлэгдсэн нэрснээс илт буй. Гэхдээ яаж очихгүй байх вэ? Найз хүүхнээ гаргуунд нь орчих уу? Хүүхэдтэй нь ганцааранг нь уу? Очих хэрэгтэй. Харин яаж очих вэ? Орцны үүдэнд хаалгач сууж байгаа. “хэнийд орох гэж явна?” гэж асууна. Будягиныд гэдгээ хэлэх хэрэгтэй болно. Тэгэнгүүт Будягиныд нэг бүсгүй ирлээ гээд хэлдэг газар руу нь утасдчихна. Тэгээд учиг хөвөрч, хэдэн жилийн өмнө Иван Григорьевич түүнийг намд элсэхэд нь батлан даалт гаргасныг олоод мэдчихнэ. Тэр хүнийг нь баривчилчихаж. Яадаг хэрэг вэ? Намын байгууллагадаа мэдэгдэх үү? Төрсөн өдрөөрөө мөн сайхан бэлэг авав аа.

Нина Грановскийн гудамж руу зургаа хагаст очив. Хүмүүс ажлаасаа ирэх үе учраас анзаарагдахгүй орчихно гэж бодож. Ашгүй, хаалгач эзгүй байж таарав.

Лена үүд нээж өгч, тэр хоёр үнсэлцэн уулзав. Лена гайхмаар тайван, ажил хэрэгч байдалтай байх аж. Хэдийгээр байранд нь хамаг юмыг нь бусниулчихсан, хоёр өрөөг нь лацадчихсан байгаа ч Ашхен Степановна бас амгалан, ажил хэрэгч янзтай байв.

-Айх хэрэггүй. Бид маргааш Серафимовичийн гудамжны, Засгийн газрын байранд нүүж орох ёстой. Тэнд бидэнд нэг өрөө байр гаргаж өгсөн, Москва голын хөвөөнөөс Енисей мөрний эрэг рүү очих үдлэгээний цэг. Ингээд бэлдэцгээж байна, харж байгаа биз дээ хэмээн Лена хямсайсхийв.

-Харж байна, харж байна гэж Нина уруу царайлан өгүүлэв.

Ашхен Степановна сав суулгаа ширээн дээр хайрцаглаж, үйлчлэгч авгай шалан дээр хивс хуйлж байна.

-Энэ бүхнийг яаж нэг өрөөнд багтаана даа? гэж Нина асуув.

-Учрыг нь олчихсон. Зайлшгүй хэрэгтэй ойр зуурын юмаа өрөөнд оруулж, бусдыг нь тэр байрны няравт хадгалуулчихна. Аавыг өглөө эрт аваад явсан, гэтэл гурван цагт хүмүүс ирж, нүүх тухай мэдэгдэж, юм хумаа эмхлэх боломж олгосон, үүнээс илүү яаж хүнлэг байхав. Би амжуулаад тийшээ оччихоод ирсэн, нэгдүгээр давхарт, 14 метртэй боломжийн өрөө байна лээ. Бусад өрөөнд ч айлууд нэг нэгээрээ орсон байна, манай байшингийн танилууд хүртэл тааралдсан. Бид түлхүүрээ авчихсан.

Лена чемодан руу юмаа шидлэх зуур ам хамхихгүй ярина. Нина түүний царайг ажиглан хажууд нь хөл сэлгэн зогсов. Уруул нь жуумалзаад байх шиг хэрнээ харц нь гөлөрсөн мэт. Хэзээ ийм аманцар билээ дээ? Бас юундаа хөгжүүн зан гаргаад байна? Энэ бүхнийг нийлүүлээд бодохоор айдас хүрэм сэтгэгдэл төрнө.

Хажуугийн өрөөнд хүүхэд уйлагнав. Нина Ленаг даган тийшээ орлоо.

-За яачихаав, миний жаахан үр, жаахан шээчихээ юү, тэр юу шалихав гээд Лена хүүгээ орноос нь өргөж, нэг гараараа барьж байгаад, нөгөө гараараа даавуу, живхийг нь сурмаг солив. Хөвүүн гэрлээс анивчин нүдээ нухлаж байна.

-Манай Ванечка одоо жин тан болно.

Лена хүүгээ эргүүлж, нүүрээр нь Нина руу харуулав.

-Нина, чи хар даа, эцэг шигээ цайвар сэвлэгтэй, ямар мундаг чекист бойжиж байна, хөөрхөн чекист, муу ах нарыг баривчлана, муу эгч нарыг бас баривчлана, миний муу мундаг бяцхан чекист.

Нина дэмий л шал шагайна. Лена юу ярьж буйгаа ч мэдэхгүй, со-лиорчихож гэлтэй. Гэнэт нэг жигтэй юм хэлж Нинаг эвгүй байдалд оруулаад, тэр хоёрын харилцаа үүрд тасрах вий

гэхээс гол руу нь хүйтэн оргив.

-Иван Григорьевич юу гээч болчихоо вэ?

-Иван Григорьевич... Иван Григорьевич уу... Манай энэ бол Иван Иванович гээд Лена хүүхдээ хэвтүүлж хучив. -Иван Иванович гэж өвөөгөөр нь нэрлэсэн юм...

-Леночка, би мэднэ шүү дээ гэж Нина түүний үгийг эелдэгхэн таслав.

-Өө, тийм шүү дээ, би бүр мартчихаж. Иван Григорьевичийг баривчилж аваад явчихсан. Яагаад? Яагаад бусад хүнийг баривчилж авч явж байна, тэр л шалтгаанаар. Манай байшингийнхны талыг аль хэдийн аваад явчихсан. Тэрээр хүүгээ унтуулах гэж орыг нь зөөлөн бүүвэйлнэ. -Юу болж байгааг чи харахгүй байна гэж үү? хүнд аж үйлдвэрийн ардын комиссариатад ганцхан нөхөр Оржоникизе үлдсэн. Бусад нь бүгд баригдсан, удахгүй шүүгдэнэ. Шүүнэ, буудан ална гээд Лена дахиад хямсайсхийв.

-Лена, чи хүүхдийнхээ юмыг эмхэлчихсэн үү гэж Ашхен Степановна асуув.

-Арай үгүй байна.

-Түргэвчлээрэй.

-Та нарт юмаа эмхлэх хоёр өдөр өгч болоогүй юм байх даа?

Нина ийм бодлогогүй асуулт тавьсандаа хожим өөрийгөө их зүхсэн.

-Мөн ч гэнэхэн амьтан бол доо. хэн нэгэн манай байранд орох гэхээс байж ядаж байгааг үнэхээр ойлгохгүй байна гэж үү? Серебряковыг баривчлаад шүүх хурал ч болоогүй байхад Андрей Януарьевич тэдний зуслангийн байранд нь хэзээний нүүгээд орчихсон гэнэ лээ. Ямар вэ дээ? Манай шүүх цаазны нүүр царай юу?

-Бас юуных нь Андрей Януарьевич вэ? гэж Нина асуухдаа Ленагийн хариултыг гадарлан дотор нь хүйтэн оргив.

-Вышинский гэж цаадах нь тас татах мэт хэлэв.

Нина час улайх нь тэр.

-Чи яах гэж элдэв цуу яриа хураадаг юм бэ?! Чамайг танихын арга алга!

Лена түүн рүү хяламхийв.

-Цуу ч, мэдээж, цуу, эргэн тойронд хов живнээс өөр юм алга, харин бусад бүх юм ёс жаягаараа байна.

Иймэрхүү амьсгаан дээр салж явмааргүй санагдав.

-Владлен хаачаав? гэж Нина асуулаа.

-Найз нар руугаа явсан. Тэд нар маргааш ирж манайхыг нүүлгэлцэнэ, тэр тухай тохирч яваа.

Нина золтой л уйлчихсангүй. Арван нэгтэй хүүхдүүд. Тус болох улс ердөө л тэд байх нь. Өөрөө даанч завгүй, олон цагтай, сургууль нь явуулахгүй, түүнээс биш ирж туслалгүй яахав хэмээн Нина чин сэтгэлээсээ учирлав.

-Би бүгдийг нь ойлгож байна, ирсэн чинь бол оо, баярлалаа гэж Лена өгүүлэв.

-Баярлалаа хэмээн Ашхен Степановна охиноо давтах мэт хэлэв.

Энэ бүхнээс сэтгэлд нэг л эвгүй булингар үлдлээ. Ленаг урьдын адил хайрлаж байвч, тэдний харилцаа ингээд тасрах нь энэ, энэ бол тодорхой. Баригдагсдын ар гэрийнхэн байдаг Серафимовичийн гудамжны байр руу очиж болохгүй. Нина Иван Григорьевичийг хэзээний бурханчлан хүндэтгэдэг билээ. Ард түмнээс гаралтай жинхэнэ коммунист, большевик, намын ахмад гишүүн. Тэгвэл одоо шүүх хурлууд дээр яргачин, гэмт хэрэгтэн гэгдэн яллуулж байгаа хүмүүс намын ахмад гишүүд биш юм уу, ард түмэн тэднийг жинхэнэ коммунист, большевикууд гэж үзэж байгаагүй бил үү? Үзэж байсан. Нина өөрөө ч тэгж үзэж байсан. Гэтэл одоо тэдний хэргээ хүлээснийг уншихаар үстэй толгой өрвийгөөд ирэх юм. Иван Григорьевич нунтагласан шил хүүхдийн хоолонд холь гэх буюу худагт хор хий гэж тушаал өгч байна гэдгийг төсөөлөхийн арга даанч байхгүй. Гэхдээ, нөгөө талаас, Тэрээр бараг арван жил хилийн чанадад суусан, Ашхен Степановнагийн огтхон ч гадарлахгүй байгаа ямар нэг даалгаврыг биелүүлсэн байж болох. Тэрээр эх орноосоо урвасан, тагнуул хийсэн гэдгээ хүлээснийг Нина сониноос олж уншвал юу хэлэх болж байна? Намд элсэхдээ яагаад заавал Будягинаар батлан даалт гаргуулсан юм бэ? гэж түүнээс асуух нь гарцаагүй. Тэрээр байсан юмыг байснаар нь хэлж таарна: Будягин батлан даахыг ө ө р ө ө санал болгосон. Оржоникизегийн орлогч, ахмад большевик өөрийг нь улс төрийн хувьд өсч бойжсоныг үнэлсэн нь түүнд аятайхан санагдалгүй яахав. За тэгж саная, тэгвэл баригдса-ныг нь мэдсэн байж бидэнд яагаад хэлсэнгүй вэ? гэж нөгөөдүүл чинь өөнтөглөнө. Нуух гэж оролдоо юу? гэнэ. Чухамхүү энэ асуултыг гаргуулахгүй байх хэрэгтэй. Тийм учраас өөрөө эхлэж очоод намын байгууллагадаа хэлье. Лена Будягинатай нэг ангид байсан, тэднийд очиж байсан, тэгээд эцэгтэй нь танилцсан энэ тэрийг буруутгахгүй юм байгаа биз дээ. Ингэхэд, Будягин тэдний сургууль дээр ахмад большевикуудын дурсамжийн үдэшлэгт оролцож үг хэлж байсан. Үүнийг марталгүй дурдах юм шүү.

Тэгэвч аюулхай руу нь гөхөлзөөд болж өгөх биш. Алевтина Федоровнатай зөвлөх үү? Нина түүнд л үг дуугүй итгэдэг билээ.

Нина хичээлийнхээ дараа түүний өрөө рүү шагайв.

-Тавхан минут тань дээр ороод гарч болох уу?

-Ор л доо, суу, чамаар юу байна?

Нина Будягины баригдсан тухай ярьж, түүнээс батлан даалт авсан тухайгаа намын

байгууллагад мэдэгдэх эсэх тухай зөвлөлгөө хүсч байгаагаа хэлэхэд Алевтина,

-түүний баригдсан гэдгийг чи хаанаас мэдээв? гэж асуув.

-Тэдний охин Лена надад утсаар хэлсэн юм. Бид нар нэг ангид байсан, та бараг санах байх.

Алевтина сүүлчийнх нь өгүүлбэрийг сонсоогүй мэт царайлж,

-Та хоёр харилцаатай байдаг юм уу? гэв.

-Яахав, цуг сурч байсан... Найз...

-Цаадах чинь чам руу яах гэж утасдсан юм? Урьдчилан сануулаа юу?

Нина дөнгөж сая л цаад учрыг нь ойлгов. Тэнгэр минь, би чинь ямар тэнэг толгой вэ? Битгий ирээрэй, битгий утасдаарай, юу ч мэдээгүй царайтай байгаарай, ямар нэгэн хэргийн хоморгонд орчих вий гэж Лена дохио өгч урьдчилан сануулсан байна шүү дээ. Гэтэл мань хүн нэг их навсганаж тавьж хүрсэн байна.

-Өөрөө л сайн бод. Хэрвээ чи Будягиныхантай харилцаатай байдаг бол энэ тухай, мэдээж, намын байгууллагадаа мэдэгдэх ёстой. Хэрвээ харилцаагүй байсан бол юу ч мэдэгдэх хэрэггүй гэж бодож байна. Ер нь бол ч и н и й л хэрэг юм чинь өөрөө л шийд гэж Алевтина Федоровна хэлжээ.

Нина Алевтина Федоровнагийн зөвлөлгөөг удаан эрэгцүүлж бодов. Будягин түүнийг батлан даасныг хэн санаж байгаа билээ?

Ленагийн очсоныг нь хэн мэдэж байгаа билээ? хэн ч мэдэхгүй. Харин Будягины нэр сонинд гараад ирвэл намын байгууллагадаа очиж хэлнэ. Одоо? Төлгөн хуц элгэн хад мөргөхийн үлгэр болохын хэрэг юу байна?

Хүлээнэдэг хэрэг. Харин ар талаа сайн төвхнүүлэх хэрэгтэй. Үгүйдээн, гэртээ хэрүүл уруулгүй болох юмсан. Хичнээн ярих вэ, ажил хэрэг болгох цаг болсон.

Гэтэл байр солих нь амаргүй ажил болж таарав. Нэг өрөөгөөр хоёрыг солих бүр ч яггүй. Нинагийн өгсөн зарлалын дагуу амьтан хүн утасдаж эхлэв. Гайгүй юмнаас сольчих санаатай, боломжийн санал одоо хэр алга. Уул нь Нинад бол юу ч хамаагүй л дээ, даанч Варя... Нинагийн утсаар юун тухай ярьж буйг сонсоод, Варя,

-Чи байраа солих гэж байгаа юм уу гэж асуув.

-Тийм. Чи бид хоёрын хувьд тэгсэн нь дээр гэж бодож байна.

-Би ч бас тэгж бодож байна, гэхдээ байшингийн зоорь, нийтийн байр ч юм уу, эсвэл хотын захын тосгон руу би очихгүй шүү, үүнийг мэдэж аваарай гэж Варя аагархжээ.

Ямар цагт утасдахыг Нина зарлал дээрээ бичсэн боловч өглөө, орой, өдөр, шөнөгүй утасдаад амар заяа үзүүлэх юм биш. Хөршүүд нь тээршааж байгаа нь илт, ер нь энэ санаа зангууны үлгэр болов.

Варягаас үүдэлтэй түгшүүр яваандаа ард хоцров. Алевтина Федоровна пионерын ахлах удирдагч Тамара Наседкина буюу товчоор Туся хэмээгдэгч хоёрын зөрчлөөс болж сургууль дээр өрнөсөн санамсаргүй хэрэг явдлууд урдуур нь гараад ирлээ.

Хөдөө дунд мэргэжлийн сургууль төгсөөд Москвад ямар аргаар орж ирсэн нь үл мэдэгдэх энэ комсомолын гишүүн, бүдүүлэг харанхуй, хэл амтай, ороолон шиг бүсгүйг Нина нэг нүдээр үздэггүй билээ. Алевтина Федоровна, “Үгүй гэдэггүй, царайлаг хоёртоо дулдуйдаж ирээ биз” гэж хэлсэн удаатай. Алевтина Федоровна ингэж тодорхойлсон хэрнээ түүнийг тэвчээд байдаг нь хачирхалтай. Цаадах нь пионерын хурал, цуглааныг ёсчлон явуулж, Лениний буланг чимэглэн тордож, хашгичиж харайлгаад бөөн идэвхи. Районы комсомолын хороонд нэр сайтай. Алевтина Федоровна түүнээс илүү юу шаардахав, нэг удаа “Эд нар цөмөөрөө сэнсэн дэвүүр, нэг нь нөгөөгөөсөө ялгарах юм байхгүй” гэж Нинад хэлсэн билээ.

Өнгөрсөн намраас Пушкины нас барсны 100 жилийн ойд бэлтгэж эхэлсэн юм. Туся ч тэр ажил руу тавиад орчихож. Пионерууд Пушкины шүлгийг ид цээжилж байсан үе. Нэг хүү “Өвөл, тариачин баярлан цэнгэхүйд...” хэмээн эхлэж. Гэтэл Туся түүнийг тас дайрах нь тэр:

-Тариачин баярлаж цэнгэнэ гэж байхгүй. Хамжлагат ёсны үед тариачин цэнгэхтэй мантай

байсан.

Тэгээд өөр шүлэг цээжлэхийг тушаажээ.

Энэ мэдээ Алевтина Федоровнагийн сонорт хүрч, Тэрээр багш на-рын зөвлөлгөөн дээр Тусяг нэлээд хорон шүүмжлээд, ойд зориулсан үдэшлэгийн бэлтгэлд оролцохыг хоригложээ.

-Ойд бэлтгэх ажил районы комсомолын хорооны төлөвлөгөөнд орсон, та намайг хориглож чадахгүй гэж Туся санаандгүй шазруун өчих нь тэр.

Алевтина Федоровна юм хэлэлгүй түүн рүү харснаа, хавтас-наасаа нэг сонин гаргаж дэлгээд, хэрэгтэй газраа олж улаан харандаагаар дугуйлаад Тусяд өгөв.

-Унш. Дуулдахаар уншаарай.

Туся унших уу, яахав гэж тээнэгэлзэж буй нь илт. Том ширээ тойрон суусан ахмад багш нар түүнийг чимээгүй харцгаана.

-Би үүнийг аль хэдийн уншсан гэж Туся зөрөв.

-Унших дургүй байна уу, за яахав, бид өөрснөө уншихья гэж Алевтина Федоровна хэлээд, нүднийхээ шилийг засч, тогтуухан нухацтай уншив:

“Сургууль дээрх пионерын бүх ажил захирлын зөвшөөрлөөр явагдах ёстой. Пионерын ажил бол сургууль дээрх хүмүүжлийн нийт ажлын нэг хэсэг мөн. Комсомол, пионерын байгууллагын олон нийтийн ажил сурлагын чанарын төлөө тэмцэлд чиглэсэн байвал зохино”.

Тэрээр сониноо эвхээд хавтсанд даа буцааж хийв.

-Чи энэ тогтоолыг зөвшөөрч байна уу?

-Зөвшөөрч байна хэмээн Туся шал шагайн шивэгнэв.

-Тэгвэл түүнийг биелүүл. Эс биелүүлвэл ажлаа өөрчлөх хэрэг болно шүү.

Гэвч хэрэг явдал үүгээр дууссангүй.

1936 оны арван хоёрдугаар сарын 1-нд Кировыг алсны хоёр жилийн ой тохиов.

Пионерын цуглаан дээр Туся энэ аюумшигт хэргийн тухай ярьжээ. Дараа нь гуравдугаар ангийн сурагч Козловт Кировын бага насны тухай номноос нэг хуудас унших үүрэг өгөв. Тэгээд Козлов номоо дөнгөж нээтэл тэдний ангийн Глазов,

-Тэгвэл, энүүний эцэг Кировыг алсан! гэж хашгирав.

Козлов уйлчих нь тэр:

-Худлаа! Миний эцэг хэнийг ч алаагүй.

-Тэгвэл яасан гэж эцгийг чинь буудан алсан юм бэ? Яасан гэж? Кировыг алсны төлөө биш гэж үү? хэмээн Глазов лавшруулав.

-Эцгийг чинь буудан алсан юм уу? гэж Туся асуув.

-Тийм гэж Козлов толгой дохиод шүлсээ залгив.

-Тэгвэл чи үнэхээр Кировын тухай уншиж болохгүй, суудалдаа очиж суу гээд Туся түүний гараас номыг нь авлаа.

Энэ тухай дахиад яриа болжээ. Козловын эцгийг “ардын дайсан”

гэж зарласан нь үнэн, нэг шүүх хурал дээр хүртэл түүний нэр дурдагдаж байсан, гэхдээ түүний хүү, энэ бандь, энэ пионер юуны буруутай байх билээ?

Алевтина Федоровна багш нарын зөвлөлгөөн дээр иймэрхүү утгатай асуулт Тусяд тавьжээ. Эдний сургуульд хэлмэгдсэн хүмүү-сийн олон хүүхэд суралцдаг учраас энэ бол тун эмзэг асуудал. Гэхдээ хүүхдэд хэрцгий авирлахыг өөгшүүлээд байвал ямар байдал үүсч болохыг Алевтина Федоровна сайтар ойлгож байжээ.

-Глазов ардын дайсныг өөрөө хэрхэн үздэгээ илэрхийлсэн, тэр бол хүүхэд, уран цэцэн үг хэлж чадахгүй. Юу гэж бодсоноо л тэр чигээр нь хэлж. түүний амыг хамхих эрх надад байхгүй гэж Туся шаралхав.

-Харин та яагаад заавал ардын дайсны хүү Козловоор Кировын тухай уншуулах гэсэн юм бэ?

-Эцгийнх нь баригдсаныг би мэдээгүй л дээ гэж Туся өчив.

-Тийм юмыг мэдэж байх хэрэгтэй. Хэрвээ танай пионерын эцэг ардын дайсан юм бол та энэ тухай мэдэж байх үүрэгтэй. Танд үүнийг мэдэхгүй байх эрх байхгүй! Та пионер нэг бүрийн тухай бүх юмыг нь мэдэж байх үүрэгтэй, хэрвээ мэдэхгүй бол энэ алба таны хийх ажил биш гэснээ Алевтина ширээг тойруулан ширүүн хараад, -Кировыг алсны ойн өдөр ардын дайсанд индэр өгнө гэж байж болох уу, та минь! хэмээн толгой сэгсрэв.

Туся хэлээ хазав. Намын хэрүүлээр башир суусан хөгшин коммунист авгайг энэ удаа дийлсэнгүй.

Гэтэл хөгшин коммунист авгай нь залуу хүүхний чадварыг дутуу үнэлсэн байжээ.

Хэд хоногийн дараа Туся пионерын шугаман жагсаал дээр ЗИС-ийн инженерийн хүү, хоёрдугаар ангийн сурагч Борька Кауфманыг жагсаалын өмнө зогсоож байгаад, бүх хүүхдийг албадан, “Борягийн аав-ардын дайсан”, “Борягийн аав-ардын дайсан” гэж хоолой нийлүүлэн хашгируулжээ. Жаахан Боря уйлчихгүйг хичээн, хөмхийгөө зуун номхон зогсоно. Тэгж тэгж тэсэлгүй мэгшиж эхэлсэнд жагсаал баярлан хөөрч, “Борягийн аав-ардын дайсан” хэмээн улам сүртэй нирхийлгэв.

Нүдтэй хүн харах юм биш. Нина уурандаа багтарч ойчих шахсан боловч, Тусяг хүүхдүүдийн нүүрэн дээр загнаж чадсангүй, сурганы номонд таарахгүйн гадна түүний ажилд хөндлөнгөөс оролцох эрх ч бас байхгүй. Алевтина Федоровна шугаман жагсаалын дэргэдүүр хөшөө шиг царайлан өнгөрч өрөө рүүгээ оров.

Нина ч дагаад орчихов.

Алевтина Федоровна пальтогоо тайлж булангийн өлгүүрт өлгөөд, эргэж харалгүй,

-Чи яах гэв? гэж асуув.

- Алевтина Федоровна... Ийм шугаман жагсаал... эд нар чинь хүүхдүүд шүү дээ...

-Эд нар хүүхдүүд гэдгийг би өөрөө мэднэ гэж Алевтина эрсхэн хариулав.

Ийм шугаман жагсаалыг районы комсомолын хорооны заавраар хийж байгаа, хойшид ч хийх болно гэж Туся захиралд мэдэгдсэн юм байж. Хэрвээ Алевтина Федоровна өөрт нь итгэхгүй байгаа бол районы комсомолын хорооны нарийн бичгийн даргын утас энэ байна, та шалгаж болно шүү дээ гэсэн юм байж.

Алевтина Федоровна юу гэж утасдах вэ дээ.

Дараачийн шугаман жагсаал дээр Лиля Евдокимоваг жагсаалын өмнө гаргажээ. Дахиад нэгэн дуугаар “Лилягийн аав-ардын дайсан”, “Лилягийн аав-ардын дайсан” гэж хашгирцгааж. Арван нэгтэй Лиля газар шагайн зогссон ч уйлаагүй, харин шугаман жагсаалын дараа цүнхээ шүүрч аваад, хичээлээс яваад өгчээ.

Ийм жүжиг өдөр болгон тохиох болов. Сурлагын чанар муудаж, хүүхдүүд шугаман жагсаалаас мултрах санаатай хичээлээ таслана. Гэвч тийм арга нэмэр болж байгаа юм алга. Тусягийн гарт хөдөлбөргүй нэрсийн жагсаалт байгаа нь илэрхий.

Алеша Перевозниковын “ээлж” ирснийг Нина өглөө сургуульдаа ирж яваад санамсаргүй мэджээ. Алеша түүний хайртай сурагч. Хойт эцэгтэйгээ байдаг, час улаан хацартай, бүрэг хүүхэд. Ээж нь хилийн чанадад нэг газар ажилладаг гэх. Алеша Испанид авахуулсан нэг зураг авчирч үзүүлсэн удаатай. Яг Алеша шиг шулуухан сормуустай, гайхам хөөрхөн хүүхэн цэцэг тэврэн инээмсэглэж байгаа зураг.

Сарын өмнө хойт эцэг нь баривчлагдаж, Алешаг Красные ворота хавьд суудаг нагац эгч нь өөр дээрээ авсан, түүнээс хойш хүү хичээлээс хожимдох болж, Нина ангийн багшийн хувьд нааш харж инээн, цааш харж уйлан байж харилцах дэвгэрт нь анхааруулга бичдэг билээ. Дараа нь энэ байдал засарсан, Алеша ээж нь ирсэн гэж хэлсэн. Нина тэр өглөө сургуулийнхаа тэнд ирээд анх удаа ээжийг нь харжээ. Москвагийнхны нүдэнд дасаагүй үслэг урт пальтотой, толгой нүцгэн тэр хүүхэн Алешаг мөрөөр нь тэврэн, өөр рүүгээ энхрийлэн шахаж явахдаа, шугаман жагсаал дээр л битгий уйлаарай гэж дахин дахин гуйж байж. Яаж энэ хүүхний нүд рүү харахав, Алешатай харц мөргөлдчихвөл яана гэхээс Нина өөрийн эрхгүй алхаагаа саажээ.

Гэтэл түүнээс хойш хэд хоногийн дараа Алешагийн ээж гүрээнийхээ судсыг огтолчихоод зургаан давхраас нисч амиа хорложээ. Үүнийг нүдээрээ үзсэн сургуулийн хашаачин татар авгай, дорхноо бөөн амьтан овоорч, үхсэн хүүхний гараас гадаад цаг, бөгж энэ тэрийг нь хуу мулталж авсан тухай ярьсан болой.

Сургууль дээр Алеша үзэгдэхээ больсон.

Пионерын шугаман жагсалаас гадна ахлах ангийнхнийг комсо-молоос хөөдөг шинэ ажил нэмэгдэв. Кремлийн комендант байсан Петерсоны охин Ираг хамгийн түрүүнд хөөлөө. Тэрээр өвчтэй байсан учраас хуралд ирээгүй. түүний найз охин Валя Щеславская гишүүний асуудлыг заавал өөрийг нь байлцуулж хэлэлцэх ёстой гэж хэлж. Тэгтэл орох орохгүй нүх рүү байнга шургалж явдаг Шурка Максимов, “Чи комсомолын батлахыг дайсны өвөрт дахиад долоо хоног байлгах гээ юү?” гэж хашгирав. “Тэр чинь дайсан биш, дайсны охин” гэж Валя зөрөв. Ираг комсомолоос хөөж, Валяг дайсантай эвлэрсэн хэмээн донгоджээ. Маргааш нь комсомолын үүрийн дарга Тоня Чегодаева, урд шөнө эцгийг нь баривчилсан учир үүрийн даргын үүрэгт ажлаас чөлөөлж өгөхийг хүссэн өргөдөл гаргав. Тоняг хурал дээр гаргаж ирээд, энгэрээс нь комсомолын тэмдэг, ГТО (Готов к труду и обороне-Хөдөлмөр, батлан хамгаалахад бэлхэн), ГСО (Готов к санитарной обороне-Ариун цэврийн хамгаалалтад бэлхэн), ВС (Ворошиловский стрелок-Ворошиловын мэргэн бууч) энэ тэрийн тэмдэгнүүдийг хураан авч комсомолоос хөөлөө. Тоня сургуулийн магнай сурагч, идэвхтэн, онц сурлагатны гэрчилгээ гарцаагүй авах хүүхэд байжээ. түүнийгээ авч чадаагүй: Долоо хоногийн дараа ээжийнхээ хамт Астрахань руу цөлөгджээ.

Онц сурлагатны гэрчилгээ гарцаагүй авах ёстой хоёрдахь сурагч Юра Беленький өөр сургуульд шилжжээ. Баривчлагдсан эцэг эхээсээ татгалз гэж комсомолын хурал дээр шаардсаныг хүлээж аваагүй, Шурка Максимов комсомолын тэмдгийг нь хуу татах санаатай үсэрч очиход, гарыг нь цохиж холдуулаад, тэмдгээ өөрөө эрэгдэн тайлж ширээн дээр тавьчихаад, хурлаа хаяж, хаалга саван одсон аж. түүний гар дээр охин дүү нь хоцорсон, амь зуухын эрхээр шөнийн цагт талхны машины жолооч хийж талх зөөдөг болсныг Алевтина Федоровна хожим сонсчээ.

Алевтина Федоровна ойрноос бүр турчихаж. Салдаггүй ганц англи костюм нь элбэгдэн хүлхийж, нүүрээр нь улаан толбо туурчээ.

Тэр хооронд хэрэг явдал өрнөсөөр л.

Нэгдүгээр сард, Лениний нас барсны ойгоор аравдугаар ангийн сурагч Юра Афанасьев илтгэл тавьж байгаад хэл нь хальтран, “Ленин нас барав” гэхийн оронд “Сталин нас барав” гээд хэлчихэж. Тэрээр дорхноо залруулан хэлсэн төдийгүй дараа нь яг зөв бичээтэй байгаа тэмдэглэлээ үзүүлж харуулсан ч гэсэн комсомолоос хөөгджээ. Сургуулиас хөөхөөр завдсан ч, хэдхэн сар үлдсэн гэдгээр шалтаглан, Алевтина Федоровна “Улс төрийн ноцтой алдаа болж хувирсан анхаарлагагүй байдал гаргасны” учир хэмээн донгодож байж түүнийг авч үлдсэн аж.

Тэгтэл яг маргааш нь бас нэг хэрэг мандав. Аравдугаар ангийн сурагч Трищенко, Свидерский хоёр улаан буланд төмөр бөмбөлөгтэй жижигхэн бильярдаар тоглож байжээ. Гэтэл нэг

бөмбөлөг, юунаас ч юм бэ, ойж үсрээд хажууханд байсан Сталины гөлтгөнөн цээж баримлыг онож, хамрыг нь сэвтгээчихэж. Энэ тухай Алевтина Федоровнад мэдэгдээд, тэр баримлыг шуудайд хийж агуулахад аваачжээ.

Өглөө нь аж ахуйн эрхлэгч Яков Иванович аравдугаар ангийн Парамонов, Куманин гэдэг хоёр хүүхдийг дагуулан, шефийнхээ гаргаж өгсөн ГАЗ-АА машинаар шинэ цээж баримал авахаар завод руу явцгаав.

Барималаа авч гарын үсэг энэ тэрээ зурчихаад, Яков Иванович жолоочийн хажууд тухлан сууж, Парамонов, Куманин хоёр барим-лаа түшиж явахаар тэвшин дээр гарав. Гэтэл чулуу дэвссэн замд баримал нь ганхаад хэмх ойчихыг байг гэхийн газар алга, хүүхдүүд нэг тасархай шидмэс олоод, бүхээгний арын шилний торлосон төмрийн цаагуур сүвлэн хоёр үзүүрийг нь нааш гаргаж баримлын хүзүүгээр оосорлон зангидав.

Алдаж эндэлгүй явсаар яг их завсарлагаанаар сургуулийнхаа хашаа руу орж ирцгээв. Жолооч тэвшээ буулгатал нэг хүүхэд,

-Хөөе хараач, Сталиныг дүүжилчихэж! Сталиныг машин дээр дүүжилчихэж! гэж хашгирлаа.

Машиныг хүүхдүүд дорхноо бүчээд авах нь тэр.

Куманин, Параманов хоёр баримлаа тайлж авах гэж оролдож байтал Туся Наседкина гэнэт гарч ирээд,

-Больцгоо! хэмээн гараа савчуулан зангав.

Тэгээд өөрөө машин дээр авиран гарч, Параманов, Куманин хоёрыг түлхэж зайлуулаад, Алевтина Федоровнаг бушуухан дууд гэж хүүхдүүдэд тушаав.

Захирлын өрөө рүү хэдэн охин дайрах мэт орлоо:

-Алевтина Федоровна! Хашаа руу бушуухан очоорой. Тэнд нөхөр Сталиныг дүүжилчихсэн байна.

Алевтина Федоровна элдвийг асууж шалгаалгүй, пальтогоо өмсөөд хашаа руу гарлаа.

Задгай тэвшин дээр Туся зогсож харагдана.

Тэрээр бүхээгнээс уясан Сталины баримал руу зааж,

-Алевтина Федоровна, сонирхоорой! гэж бах нь ханасан мэт хэлэв.

-хэн ингэсэн юм бэ?

Туся хажуудаа зогсож буй Куманин, Параманов хоёр руу заав.

-Заавал уях хэрэгтэй байсан юм, тэгэхгүй бол унаад хэмхэрчих гээд байсан гэж Куманин

өгүүлэв.

-Яагаад заавал хүзүүгээр нь уясан юм бэ? гэж Туся муухай гонгинов.

-Чи битгий гонгиноод бай, өөр яаж уях юм бэ, чи тэгвэл үзүүлээтэх! гэж Парамонов мөчөөгөө өгөхгүй зөрөв.

Алевтина Федоровна машины дэргэд, жолоочтой зогсож байгаа аж ахуйн эрхлэгч Яков Иванович руу асуусан харцаар харав.

-Зам донсолгоотой юм чинь хага ойчиж мэдэх л дээ. Жолооч ч нотлоно гэж Яков Иванович тайлбарлав.

-Баримлыг буулгаж, улаан буланд аваач. Болгоомжтой ажиллаа-рай гэж Алевтина Федоровна үүрэг болгов.

-Энэ бол улс төрийн явуулга гэж Туся дүвчигнэв.

-Учрыг нь олно гэж Алевтина Федоровна товчхон хариулав.

Тэгтэл Алевтина Федоровна учрыг олох биш, харин районы намын хорооны тусгай комисс өөрийнх нь учрыг олох болчихжээ. Туся, ахлах ангийн хэсэг комсомолын гишүүдийн хамт “матааны” захиа бичсэн юм байж. Тэр мэдээлэлд Алевтина Федоровнаг пионер, комсомолын гишүүдээс ардын дайсныг зэмлэн буруушааж, шудрага уур хилэнгээ илэрхийлэх гэсэн аливаа оролдлогыг таслан зогсоодог, ардын дайсны хүүхдийг өмгөөлдөг, нөхөр Сталин нас барсан гэж хурал дээр ичих нүүргүй хэлсэн Юрий Афанасьевыг сургуулиас хөөгөөгүй, сурагч Трищенко, Свидерский хоёр эсэргүү мөн чанараа илэрхийлэн нөхөр Сталины цээж баримлыг хага цохьсон байхад түүнийг нуух гэж оролдон, баримлыг агуулахад хий, улаан буланг хаа, шинэ баримал олж ир гэж тушаасан, Трищенко, Свидерский хоёрт ямар ч арга хэмжээ аваагүй, гэтэл нөхөр Сталины шинэ цээж баримлыг аравдугаар ангийн сурагч Куманин, Парамонов хоёр машины тэвшин дээр хүзүүгээр нь дүүжилж доромжилсон, үүнийг сургууль даяараа харсан, тэр хоёрт бас ямар ч арга хэмжээ аваагүй гэхчилэн буруутгажээ.

Эдгээр болон бусад баримтууд нь сургуулийн захирлын явуулж ирсэн оппортунист чиг шугамын, тухайлбал коммунист багш нарыг сургуулиас хөөж явуулсан, тэднийг хөрөнгөтний профессор, цагаач цагаантны охин бөгөөд эдүгээ илчлэгдэн шүүгдсэн нэг баруунтны төрсөн дүү Ирина Юльевна Эйнвальд мэтийн найдваргүй, дайсагнагч этгээдүүдээр сольж байсны үр дагавар юм. Мюнхений их сургууль төгссөн, герман дипломтой физикийн багш Юренев шинжлэх ухаан дах хөрөнгөтний үзэл бодлыг явуулж байсан, утга зохиолын багш Мезенцев сурагчдыг унанги үзлээр хүмүүжүүлж, Северянин, Бальмонт, Андрей Белый нарыг шагшин магтаж, бас Боккачогийн “Декамерон”, Апулейн “Алтан илжиг” энэ тэрийн тухай ярьж, сурагчдыг янхны явдалд сургаж байсан.

Өөр бас нэг зэмлэл. Сурагч дэвтрийн хавтсан доторх “Олег цэцний” зурган дотор “Долой Сталина” (Сталин тонил) гэж нууцаар бичсэн нь илэрсэн гэнэ. Эмээлийн дөрөө нь “Д” үсэг, хажууд нь буй угалзны хэсэг “О” үсэг... Бүх сурагчийг дэвтрийн дотуур нүүрийг урж

ангийнхаа багшид өг гэж тушаасан, тэд нар түүнийг хичээлийн эрхлэгчид өгөх ёстой. Гэвч Тусягийн мэдээлэлд бичсэнээр бол, 250 ширхэг дэвтэр тараасан байсан, гэтэл дөнгөж 180 хуудас цугларсан, тэгэхээр дайсны 70 ширхэг зураг сурагчдын гар дээр үлдсэн аж. Тэгтэл сургуулийн захирал, коммунист хүн үүнийг юу ч болоогүй мэт амарлингуй харж байна.

Мэдээлэлд аливаа сургуульд байдаг бусад олон дутагдлыг дурджээ. Хэдий хаа сайгүй байдаг ч гэсэн улс төрийн зэмлэлүүдтэй хослохоороо бас л ёрын сонсогдох аж.

Комиссынхон бүх багш нар, үйлчилгээний ажилчид, комсомолын гишүүд, ахлах ангийн олон сурагчдыг шалгаажээ. Бүгдтэй нь ганцаарчлан уулзаж.

Нинатай ч бас ганцаарчлан ярилцжээ.

Тэрээр комиссын даргыг танихгүй, бодвол, районы намын хорооны ажилтан байх. Комиссын хоёр гишүүнийг бол танина, нэг нь районы боловсролын хэлтсийн орлогч эрхлэгч, нөгөө нь 86 дугаар сургуулийн утга зохиолын багш, залуухан хүүхэн.

Нина хүндээ хөнгөнөөс өгөх бодолгүй байв. Алевтина Федоровнаг намын маш шудрага гишүүн гэж итгэдгийн хувьд түүний талыг хатуу барив. Тусягийн муулсан бол хорон санаатай явуулга. Алевтина Федоровна түүнд Пушкины тухай зөв зүйтэй анхааруулсанд гоморхсондоо ингэж байна. “Өвөл, тариачин баярлаж цэнгэхүйд...” гэдэг шүлэгт Наседкинагийн өгч байгаа тайлбар бол манай намын нэгэнт буруушаасан хориод оны бүдүүлэг социологизмын гулгидас. “Ардын дайсан”-ы арван настай хүүхдүүдийг доромжлон шоолох нь сурганы номонд таарахгүй, “хүү нь эцгийнхээ төлөө хариуцлага хүлээхгүй” гэж нөхөр Сталин хэлсэн, үүнийг Туся мэдэж байвал зохилтой, ийм жүжиг тавьж болохгүй. Нөхөр Сталины цээж барималын явдал бол санамсаргүй болсон зүйл. Мэдээж, улаан буланд бильярдны ширээ байлгах ёсгүй, энэ бол алдаа, гэхдээ тэр ширээ тэнд олон жил байсан, бөмбөлөг үсэрсэн нь санаандгүй зүйл, би үүнд итгэж байна, бусад хүн ч цөм тэгж нотлож байгаа. Машинаар тээсэн баримлын тухайд гэвэл унагаад хагалчихсан бол долоон дор юм болох байсан, харин ч хүүхдүүд ганц арга олж уясан байна. Харин сайн бодолгүй, эвгүй уясан нь тусгүй юм болсон. Санаандгүй л болсон явдлууд. Багш нарын тухай ярья. Ирина Юльевна нарийн мэрэгшсэн сайн сурган хүмүүжүүлэгч. Эцэг нь утга зохиолын нэрт судлаач, цагаачлан гарсан нь үнэн, гэтэл Ирина Юльевна өөрөө хилийн чанад руу явчихаагүй шүү дээ. Ах нь баруунтан гэж буруушаагдсан, харин Ирина Юльевна бол нам бус. За, утга зохиолын багш Мезенцев байна... Хичээл дээр нь байж үзээгүй учраас тодорхой хэлэх юм алга, гэхдээ хичээлийн хөтөлбөрийн дагуу “Декамерон”-ыг ерөнхийд нь танилцуулах ёстой. Апулейн тухайд гэвэл энэ асуудал Пушкины найргийг унших явцад үүссэн гэнэ лээ: “Апулейг бахдан уншдаг хэрнээ Цицероныг үзээ ч үгүй...” Нэг сурагч Апулей гэж хэн болохыг асуусан учраас багш нь тэр тухай зүй зохисоор товчхон ярьж өгтөл, зарим нэг хүүхэд, бодвол Апулейг уншсан хүүхдүүд биз, асуулт тавьж инээлдмэгц Мезенцев энэ асуудлыг тэр даруй хаасан юм билээ. Апулей гэж хэн болохыг яаж тайлбарлахгүй орхихов.

Нина бүх юмыг ийнхүү учир начиртай, тайван тайлбарлажээ. Мэдээж, сургуульд нь дутагдал байгаа, дутагдалгүй газар гэж байхгүй. Гэхдээ улс төр, сурганы ажлын чиг шугам хэзээ ч зөв байсан, нам, засгаас сургуулийн талаар гаргасан тогтоол шийдвэрт бүрэн дүүрэн нийцэж ирсэн хэмээн нэмж хэлсэн аж.

Комиссын гишүүд Нинаг анхааралтай сонсоцгоож. Районы боловсролын хэлтсийн хүүхэн түүний хариултыг тэмдэглэж авч. Тэгээд нэг ч юм асуулгүй, талархал илэрхийлээд түүнийг явуулжээ.

Тэрээр бүх юм тодорхой болж учир нь олдоно гэсэн итгэлтэй, сэтгэл уужран тэндээс гарчээ. Сонор сэрэмж хэрэгтэй нь хэрэгтэй, гэхдээ нүд хуурах биш, жинхэнэ намч сонор сэрэмж хэрэгтэй. Дайснаа хайх хэрэгтэй, гэхдээ Ленин, Сталины үзэл санаанд үнэнч, намын чин шудрага гишүүн Алевтина Федоровнаг сэжиглэх биш, жинхэнэ дайснаа хайх хэрэгтэй. Ер нь нэг муу хоосон толгойтой, яс хаягч хүүхнээс болж сурган хүмүүжүүлэгчид, сурагчдын эрүүлсаруул хамт олныг үймүүлүүлээд байж хэрхэвч болохгүй.

Гэтэл хамт олон үймэлдээд байх нь тэр. Ул тавхайг чинь шагайгаад байвал ажил хийх хэцүү. Гэхдээ энэ тухай нэг их үгэлцгээхгүй, бие биендээ хоёр гуравхан үг хэлэхээс цаашгүй. Нина хэдийгээр бүх хүн комиссынхонд өөр шиг нь ярьсан гэж бодож байвч, нөгөө учир нь олдоно гэсэн дотоод итгэл нь ууршиж замхрав. Яах аргагүй бусармаг цаг үе, гэхдээ багш нар болж байна, бүтэж байна хэмээн хичээл номоо заадаг янзаараа заацгаана. Нинагийн бодлоор бол, сэтгэлийн сэвгүй улс яг л ийм байх ёстой.

Сэтгэл сэвтсэн хүн үгүй ч, сургуулийн амьдрал цаанаа л нэг биш. Урьд хожид хурц асуудал, тэр ч бүү хэл, хямралт байдал үүсч байсныг алийг тэр гэх вэ, гэхдээ тэр үед багш нар сэтгэл санаагаа уудлан ярьж, маргаж мэтгэлцэн үг сөрж, заримдаа муудалцдаг ч гэсэн дараа нь эвлэрцгээдэг билээ. Одоо бол юун маргах муудалдах, багш нарын өрөө дүлийрч чимээгүй оргиод тун эвгүй, “комисс” гэдэг үгийг дурсдаг хүн алга, юу гэж асуусан, юу гэж хариулснаа ярьдаг хүн алга.

Алевтина Федоровна урьдын адил хатуу гараар сургуулиа удирдаж байвч, үг дуу нь цөөрч, царай нь голдуу баргар явах болжээ.

Нина, мэдээж, комисс дээр болсон яриаг түүнд нэгд нэгэнгүй ярьсан, Алевтина Федоровна чив чимээгүй ширээн дээрх бэхний сав руу гөлрөн байж сонссон. Нина, тэгэхэд, яасныг бүү мэд, түүнийг гэнэтхэн өрөвдсөн, эр нөхөр ч, үр хүүхэд ч байхгүй, ах дүү, амраг садан ч байхгүй, орь ганцаараа амьтан. хэндээ гомдоллож, хэнээсээ зөвлөлгөө авахсан билээ? Өрөвдсөндөө хоолой нь хүртэл чичирсэн, гэвч Алевтина огт тоолгүй,

-За, тийм байж, яг зүйтэй ярьсан байна гэж хэнэггүй өгүүлжээ.

Нелли Владимирова Викад Парис руу явахынх нь өмнө хэдэн чухал сургаал айлджээ:

-Цагаачидтай битгий нийлээрэй, цаадуул чинь гуйлгачингууд. Баахан өргөл барьц нэхнэ. Ядуу зүдүү, өнчин өрөөсөн хүмүүс, бэлэвсэн авгай нарт зориулж гуйна, оршуулга, ой мой гэж нэхнэ, сүм барина, хүүхдийн баяр хийнэ гэж гуйна, буяных, халамжийнх энэ тэр гэсэн элдэв балай зөвлөлийнхөө гишүүн болгочихно, энэ бүхэнд сохор зоосны үнэ цэнэ байхгүй. Цаадуул чинь хоорондоо эцэс төгсгөлгүй хэмлэлцэнэ, бие биенийгээ зөвлөлтийн тагнуул гэж зарлана, тэр хараал хэрүүл рүүгээ татаад оруулчихна л гэж мэдээрэй гээд Нелли тамхиа соров. - Тэднээс шууд тусгаарла, ямар ч холбоо сүлбээ тогтоож болохгүй, чи бол цагаачин биш, франц хүний гэргий, тийм учраас франц хүүхэн шиг л байх хэрэгтэй, Шарль танил тал ихтэй нь гарцаагүй, тэр нийгэм рүү нь л орж явчих, Шарль ямар манай муу Жорж шиг наймаачин биш, тэр чинь язгууртан, тэр чинь “де” шүү дээ.

Нелли “де”-д үнэхээр бишрэнэ.

-За, бас хэмээн Нелли үргэлжлүүлэв. -Хэрээ сайн мэдэж бай, яаж ийгээд нэг жил тэсвэл, бидэнд шингэчихсэн барааны өлсгөлөн хар аяндаа арилна. Элдэв новш руу нүүр нүдгүй бүү зүтгэл, ариг гамтай хүн гэдгээ Шарльд харуул. Францчууд харам талдаа шүү, үүнийг мартаж болохгүй, хямгатай байх нь дээр. Тэгж гэмээ нь Шарлийн сэтгэлд нийцнэ. Гэхдээ цаадуул чинь нэрлэхүү: ясны франц хүн бол авгайгаа бусдынхаас доогуур байлгана гэж заяа нь байхгүй. Чи өөртөө зориулж хичнээн бага үрнэ, нөхөр чинь чиний төлөө төдийчинээ их үрнэ.

Нелли өрөөн дотуураа холхих зуур ийнхүү эрэгцүүлэн сургамж айлдана. Ясархаг өндөр хүүхэн... Азрага аа азрага! Гэтэл харчуул хошуураад салдаггүй юм... Нууц нь юунд байна аа? Гэхдээ сайн хүүхэн, бараг амь нэгтэй ч гэж хэлж болно.

-Чи, мэдээж, хоол хийж чадах биш гэж Нелли асуух, сануулахын завсраар өгүүлэв.

-Чадахгүй шүү гэж Вика үнэнээ хэлэв.

-Тэр ч аргагүй! Танайх Фенятай юм чинь. Бүү санаа зов, тэнд чамайг гал зуух руу шахах хүн байхгүй, тэднийд бас Феня байж байгаа. түүнээс гадна ресторан гэж бий. Бас харчуул нь өөрснөө хоол хийх дуртай, энэ талаар лут дүйтэй шүү. Гэхдээ юухан хээхэн хийж чаддаг байх хэрэгтэй.

-Гайхуулах гэж үү? Ногоотой шөл, хүрэн манжинтай шөл, шорлог энэ тэрийг үү? гэж Вика хямсалзав. Үнэхээр ч түүний зүглэдэггүй зүг нь гал зуух.

-Ногоотой шөл, хүрэн шөл энэ тэрийг чи чадахгүй, тэр чинь нарийн урлаг, хийж сурахад их хугацаа хэрэгтэй. Шорлогны тухайд бол манайд хүртэл эрчүүдийн хийдэг ажил.

-Банш уу?

-Тэр чинь ч бас хэцүү, ажил ихтэй. Зүгээр л гар хурууны үзүүрээр түргэн зуур юмхан хийж

чаддаг байх хэрэгтэй. Театраас ирлээ, юухан амхрах хэрэгтэй боллоо гэж саная, эсвэл бүтэн сайн өдөр-үйлчлэгч байхгүй байя гэж саная, тийм үед өөрөө нөхөртөө юмхан хийгээд өгөхөд муугүй шүү дээ. Өндөг, жишээ нь, улаан лоольтой шарж болно, улаан лооль тэнд чинь жил тойрон байдаг юм, Москвагай адилгүй. Эсвэл талхны таташ хайрч болно, чи эрхбиш түүнийг чадна биз дээ? Ер нь бол францчууд өглөөгүүр зөвхөн кофе уудаг юм, гэхдээ чи иймэрхүү ойр зуурын юманд гаршчихсан байх ёстой.

-Тэгэлгүй яахав, санаж явъя, баярлалаа. Харин чи Сесиль Шустерийн утас юм уу, хаягийг мэдэх үү?

-Тэрүүгээр чи яах нь вэ? гэж Нелли сэрдхийв.

-Ямар ч гэсэн бид нэг сургуульд байсан улс.

-Ээ, бурхан минь, хүүхэд ахуйн гэнэн цайлган дурсамж хэмээн Нелли доогтой өгүүлэв. -Тэр тухай март. Сесиль аль хэдийн март-чихсан, нялуурахтай мантай байгаа. Тэр чинь одоо ажил хэргийн хүн болсон. Ингэхэд, ээж нь франц шүү дээ. Чи үүнийг мэдэх үү?

-Мэднэ.

-За тэгвэл, Сесиль нөгөө мундаг Эпштейний чинь харъяанд оччихсон, “Каролина” гэдэг загварын дэлгүүрт загвар зохион бүтээгч болчихсон мандуулж яваа. Би нэг удаа утасдаж нэрээ хэлсэн чинь утсаа хаячихна лээ. Надаас салахад амаргүйг чи мэднэ, дэлгүүрт нь тавьж хүрээд, үнэтэйгээс нь шилж байгаад хоёр даа шинэ захиалсан чинь намайг сая таньсан гэж байгаа, бод доо. Зөвлөлтийнхнөөс яагаад дөлж байна? Яагаад гэвэл тэд ядуу, цагаачид нь ч бас ядуу. түүнд бол баян захиалагчид хэрэгтэй.

-түүний дэлгүүр хаа байх вэ?

-“Каролина” гэж би чамд хэллээ шүү дээ. Шарлийг гуйвал чамайг тийш нь хүргээд өгнө. Тэнд чи Сесиль Шустерийг олж харна. Чи түүнийг танина, харин мань хүүхэн чамайг таних эсэхийг би мэдэхгүй.

Вика Нелли Владимировагийн мэргэн сургаалийг сүсэглэн хүлээж авав. мань хүн оросуудаар яах юм бэ? Оросыг санана гэсэн ном байхгүй, Оростой холбогдох юм ч алга. Ээж нь эрт нас барсан, эцэг нь удахгүй өнгөрнө, Вадим бол илжиг, түүнийг харахаас нүд хорсоно. Сургуулийн найзууд бий бил үү, хаа байна? Байхгүй, төгссөнөөс хойш нэг ч хүнтэй тааралдаагүй, бүгдийг нь мартчихсан. Москвад юу үзсэн, юугаа үлдээж байгаа билээ? Арчаагүй муусайн дэлгүүр, дотуур өмдөндөө түүртсэн Уран барилгач, алхам тутамд тохиох худал хуурмаг, увайгүй явдлууд, Шарок албадаж Маросейка руу аваачих вий гэсэн айдас...

Энэ бүхнийг орхисон! Тэрээр одоо франц хүүхэн болсон, Шарлийн ам бүлд орно, тэднүүс бэрээ гомдоолгоно гэж гонж. Гэтэл Белоруссын буудал дээр галт тэргэнд орж суусныхаа дараа, маргааш Негорелое өртөөн дээр хил, гаалийнхан элдэв шалтаг зааж буулгаад Москва буцаачих юм биш биз гэж бодонгуут дотор харлам айдаст автав. Ээ, тэнгэр минь, аварч хайрла, энэ аюулаас гэтэлгэж аль! Гэвч ийнхүү балмагдан сандарсныг нь хилийнхэн битгий

хэл Шарль ч анзаарах ёсгүй. Байдаг зориг юугаан хөвчлөн байж, үс гээг хувцас хунараа янзласхийн ихэмсэг дүрийг олов.

Негорелое өртөөн дээр тэдний купенд хилийнхэн, араас нь гаальчид орж ирэв. Хооронд нь ялгахын аргагүй, нүдэнд хүйтэн амьтад. Вика хоёр хөлөө донжтой ачсанаас өөр хөдөлсөнгүй. Шарль тэдэнд паспорт энэ тэрээ өгч, цаадуул нь тэр хоёрыг купенээс гарахыг тушаасанд Вика алгуурхан босч хонгил руу гарав. Купег нэгжсэний дараа Шарль тэр хоёр буцаж орцгоолоо.

Галт тэрэг хөдлөн хурдаа авахад, Шарль цонх руу харж,

-Полония гэв.

Тэд нар Польшийн нутагт ороод ирж. Гүйцлээ! мань хүүхэн Оросыг орхилоо, Шарль түүнийг тэр тамаас гаргалаа. Хүүхэн нөхрийнхөө мөр рүү шигдээд мэгшин уйлах нь тэр.

Хүүхэн нь эх орноосоо ингэж гуниглан салж буйд уярсан Шарль түүнийг тайвшруулах санаатай толгойг нь илбэж явна. Өөрөөс нь болж эх орноо хаялаа, өөрөөс нь болж төрөл төрөгсөдөө орхилоо, нөхрөөсөө саллаа, найз нараасаа холбоогоо таслалаа...

Вика нөхрийнхөө гарыг шүүрэн авч үнсэв. Анх удаа өөрийн эрхгүй сэтгэл алдарч байгаа нь энэ. Москвад Шарль тэр хоёр Неллигийн дунд уулздаг байсан. Жорж ажлаар яваад өдөржин эзгүй, Нелли бас нэг тийш алга болчихно, мань хоёр хоюулхнаа үлдэнэ. Шарль туршлагатай, чамбай эр, Викад аргагүй сайхан санагдана. Өөрөө туршлагаар түүнээс дутахгүй, гэхдээ нөхөртэй журамт хүүхний дүр эсгэн баялаг туршлагаа эс үзүүлэн, түүний эрхэнд орж, юу заасныг нь дорхноо сайн сурч буй мэт байвч тэгсхийгээд Шарлийн өдүүлсэн хүсэл тачаалд эз дийлдэн дуу алдана:

-О-ой, Шарль!..

Тэгээд гайхам цэнгэж, сульдаж номхорсон амьтан түүн рүү хярах мэт наалдана. Биеэ үгүйлэхгүй эрчүүд ингэхэд их дуртай байдаг юм.

Харин, одоо, энэ вагонд бол мань хүүхэн үнэхээр сэтгэл алдарч, Шарлийг гэхээс хайр юу нь бялхан цалгиж байжээ. Вика гар цүнхнээсээ алчуур гаргаж нулимсаа арчив. Тэрээр Шарлийг хэзээ ч хөөдөхгүй, чин үнэнч эхнэр нь болно. түүний сүйт бүсгүйн тухай бодол толгойд зурсхийв. Тэр зүгээс ямар нэг санаандгүй юм отоож байгаа биш биз? Юу л бол. Франц хүүхнүүд, мэдээж, хурц ухаантай, гижигдэм сэргэлэн, эрх зоргоороо амьтад, гэхдээ тэдэнд өөрийнх шиг нь намбалаг эрхэмсэг тохь, сүрлэг даруу төрх, чимээгүй дорвиллог буурь энэ тэр байхгүй, ямар ч л байсан Шарль өөрийг нь шилж. Үүрд хажуу хавирганд нь явж, гэр орныг нь төвхнүүлж, үүд сайтай сайхан айл болгож, парисынханд оросын зочломтгой зан гэж юу байдгийг үзүүлж өгнө.

Гэр орон төвхнүүлэх шаардлага гарсангүй, Викаг Бельшас (Belleshasse) гудамжнаа, эртэн цагийн байшингийн гурван давхарт нэгэн тансаг байр хүлээж байжээ. Гудамжны нэрийг Шарль “сайхан ан” гэж орчуулж өгснөөс ч үзсэн энэ хавь Парисын язгууртны хороолол болох

нь тодорхой. Засмал чулуу шигтгэсэн, том том дэнлүүтэй, Арбатаас нэлээд нарийхан тохилог гудамж.

Ширмэн угалзтай, нүсэр цагираг зэс бариултай шилэн хаалгаар гантиг шалтай үүдний уртавтар цэлгэр өрөө рүү орцгоолоо. Баруун гар талд ханын энгээр толь, зүүн гар талд хаалгачийн өрөө, хажууд нь оршин суугчдын нэрстэй самбар байна.

Вика өөрийгөө толинд зэрвэсхэн харж амжаад, малгайгаа застал, нүдний шилтэй, намхан тарган авгай Шарль руу бөндөгнөн ирж яваа нь толинд харагдав.

-C'est rous, monsiuer Charles, guelle surprise! *

Мөн тийм намхан, гэхдээ туранхай, хуниастай хормогчтой үйлчлэгч дээрээс бууж ирээд бас инээмсэглэн дуу алдав:

-Monsiuer Charles, guelle joie, guel bonheur! **

Шарль Викаг танилцуулав: -Madame Victoria, me femme. ***

Тэгэнгүүт нөгөө хоёр гараа дэлгэн шулганалдав:

-Ah, monsieur Charles, permettre - nous de vous fe'liciter! C'est un vrae plaisir de voir un tel couple. Vous e'tes si beaux! ****

Зулгуйдсан шинжгүй үнэн баяртай байна.

“Манай муухай атаа жөтөөнийхнийг бодвол бусдын жаргалд баярлаж чадаж байна шүү” гэж Вика бодов.

Хаалгач авгай тэднийг лифт рүү дөхүүлж өгөөд, Вика руу харан-гаа Шарльд дахиад нэг юм хэлэв. Шарль инээмсэглэн орчуулж өгөв.

-Байшингийн доор дарс, ил зуухны түлээ хадгалдаг зооринууд бий гэдгийг хатагтай Трюбо чамд мэдээлж байна. Бас лифт

зургадугаар давхар хүртэл явдгийг чамд урьдаас сануулья гэж байна. Долдугаар давхарт үйлчлэгчдийн өрөө байдаг юм.

Тэр хооронд хатагтай Трюбо Викаг суу гэж гараараа дохив. Лифтний хажууд улаан хамба хилэнгээр бүрсэн жижгэвтэр урт сандал, түүний дээхнэ дөрвөлжин толь бас өлгөөтэй байна. Өргөн шатан дээр улаан туузан хивс дэвсчээ.

Эхлээд үйлчлэгч авгай, нэр нь Сюзан гэдэг аж, лифтээр өгсөв. Бүхээг нь санаад оромгүй жижигхэн, тэдний чемодан арайхийж багтав. Дараа нь Вика, Шарль хоёр цуг дээшлэв.

Шатны тавцан зүймэл царсан шалтай аж. Үүдний цэлгэр өрөө мөн тийм шалтай, гадуур хувцасны босоо царсан шүүгээнүүд байна. _____

* Энэ чинь та юу, месье Шарль, яасан сонин хүн бэ!

** Месье Шарль, бөөн баяр, бөөн аз жаргал!

*** Мадам Виктория, миний авгай.

**** Өө, месье Шарль, танд баяр хүргэе! Ийм хос ч ёстой нүдний чимэг юм аа! Та хоёр ёстой гоё байна!

Сюзан нэг чемоданыг үүдний өрөөнд үлдээж, нөгөөг нь унтлагын өрөөнд оруулаад, тэгэнгээ сүлжмэл сагстай захидлуудыг Шарльд харуулав. Шарль галт тэргэнд үдийн хоол идэцгээснээ хэлж, Сюзан явахаар болов.

-Хатагтайд энд таалагдана гэж найдаж байна. Ямар нэг хэрэгцээ гарвал хэлээрэй, би өрөөндөө байж байна.

-Баярлалаа, Сюзан гэж Вика талархав.

Дараа нь Шарлийг дагуулан, бүх юмыг анхааралтай сонирхон харж байраа үзэв. Дөрвөн өрөө. Зүмбэрлэсэн угалзтай өндөр адар.

Хамгийн том өрөө нь зочных. Хоёр ширээтэй, нэг нь арьсан гадартай буйдан, зөөлөн сандлын тэнд, нөгөө нь эсрэг талын хананы тэнд. Махир хөлтэй, хилэн суудалтай, өндөр түшлэгтэй сандлууд тойруулж тавьжээ. Ийм хийцний нэрийг Вика эс мэднэ. Улаан суман модоор хийсэн төгөлдөр хуур. Хоорондоо зөрсөн хоёр зэс цагираг бүхий эртний бөмбөрцөг, номын тавиур дээр бас хоёр бөмбөрцөг харагдана.

Вика түүний нэгэнд хуруугаа хүргэж, сургуульд байхдаа газар зүйн хичээл дээр эргүүлдэг байсан шигээ түүнийг эргэлдүүлэв.

-Чиний удам сударт жуулчид байсан юм уу?

Шарль инээв.

-Чи энд олон айлд бөмбөрцөг үзнэ. Манайхан ийм заншилтай юм. Большевикууд бүх дэлхийг байлдан эзлэхийг хүсч байна, тэгвэл тэр чинь бидэнд бөмбөрцөг маягаар гэрт маань байж байна.

Зочны өрөөний цонх дотогшоо хашаа руу харжээ. Бараг шалнаас эхлээд тааз хүрч, дээгүүрээ нумарсан дугуй цонх. Шүүгээтэй бичгийн ширээн дээр жижигхэн мөнгөн сав, лааны тавиур, дотроо дугуй дугуй хонхортой аяганцар энэ тэр байна. Вика түүний зориул-гыг мэдэхгүй, үнсний сав гэж санаад тамхиа асаахдаа шүдэнзээ тийш нь хаяж, дараа нь бас тамхиныхаа үнсийг сэгсэрчээ. Шарль түүн рүү харж инээмсэглэснээ, үнсний сав авчирч өгөв.

-Манай ээж үүнийг харсан бол, “оросууд үнэт эдийг хайрла-даггүй юм байна” гэж хэлэх байсан даа.

Тэрээр гал тогоо руу очиж, нөгөө аяганцарыг угааж, арчаад шил дарс барьж ирж ёроолд нь жаахан хийгээд сэнжнээс нь барьж баахан эргүүлж тойруулахад хийн бөмбөлөгнүүд хонхруудаар тогтож байв.

-Энэ бол их хуучны эд, миний өвөөгийн юм, дарсны амт үзэхэд зориулсан аяга.

Вика байртай танилцах зуураа, Шарльд заавал хүү охин хоёр төрүүлж өгнө, тэгж гэмээ нь жинхэнэ гэр бүл болно гэж бодов. Нөхөртөө энэ тухай тэр даруй хэлэх гэснээ болив. Одоохондоо арай болоогүй, хоёр ч удаа үр хөндүүлснийг хэлэх үү, уул нь Парист онцгой сайн эмч нар байж таарна, бүх юмны эв олдоно. Өөрийгөө жирэмсэлчихсэн, хүлхгэр даашинзтай байдлаар төсөөлж бодов. Юу гэж? Өөрөө хорин тавтай, нөхөр нь гучин тавтай, арван нас бол яг таарсан зөрөө, тэр хоёроос эрүүл чийрэг сайхан хүүхдүүд гарна. Шарлийн эцэг, эх ач хүүтэй болохыг гарцаагүй мөрөөдөж байгаа, хөвүүн гэдэг чинь удам судрын үргэлжлэл, язгууртнууд энэ асуудлыг их чухалчилж үздэг, Шарль хүний ганц хүү юм чинь. Вика иймэрхүү төлөвлөгөөтэй байлаа. Тэрээр Шарль бол түүний мөрөөдлийн дээд хязгаар, сугалсан азтай ганц сугалаа нь гэдгийг сайн ойлгож байв. Хилийн чанад руу гарч л байвал тэнд очсон хойно сайжруулах арга нь олдоно гэсэн шиг хэн тааралдсантай суугаад явчихсан олон бүсгүй бий. Гэвч сайжруулсан хүн нэг ч дуулдаагүй, гагцхүү дордуулж, бүр шаар болсон сураг гардаг билээ. Викад шаар болно гэж санаа зовох юм алга, ерөөсөө л энэ хорвоо дээр түүнд Шарлиас өөр хэний ч хэрэг байхгүй.

Ажлын өрөөнд хана руу суулгаж хийсэн номын тавиурууд байна. Вика хэдийгээр ном сонирхдоггүй ч гэсэн Шарлийн дуртай, түүний ашигладаг номыг тоохгүй өнгөрвөл буруудахаа ойлголгүй яахав. Тэрээр номын шилийг хуруугаараа шилэмдэн нэрийг нь чанга чанга уншлаа. Тэр болгоныг ойлгохгүй байгаа байж мэднэ, гэхдээ францаар түгдрэхгүй уншиж байна. Номыг нь сонирхож буйд урамшсан Шарль хажууд нь инээмсэглэн зогсоно. Яльгүй буруу хазгай дуудсан ч мань хүн засч хэлж өгөхгүй, Москвад ч тэгж байсан, одоо ч тэгж байна. Шарль үүнийг тун эмзэг асуудал хэмээн, Парис хот, франц хэлний багш хоёр Викагийн дуудлагыг билүүдэх ёстой гэж үзэж байгаа ажээ. Тэрээр яг гар дор байх ёстой номнуудаа л энд байлгадаг юм гэж Викад тайлбарлав. Арван есдүгээр зууны Ларусын тайлбар толь, дөрвөн боть Littre тайлбар толь, 1860 оны жуулчлалын нэвтэрхий толь бичиг, нээлт, жуулчлалын түүх энэ тэр гээд нийтдээ тавин дөрвөн боть...

-О-ёо-ёо! Яасан олон юм бэ! гэж Вика дуу алдав.

Нэвтэрхий толины цаахна нь Монтеस्कьегийн нэг боть байна.

-Явахаасаа өмнө байранд нь тавихаа мартчихаж. Миний өрөөнд юу ч хөдөлгөхгүй гэж Сюзан бид тохирсон юм гэж Шарль өгүүлэв.

Вика ойлгосноо илэрхийлэн толгой дохив. Монтескье, Корнель, Флобер, Доде нарын зохиолын эмхтгэлүүдийг Вика зочны өрөөний тавиур дээр харсан юм. Вика Монтескье, Корнель хоёрыг ерөөсөө уншиж явсангүй, Флоберын “Хатагтай Боварийг” мэднэ, Додегийн “Тарасконы Тартаренийг” дөнгөж дунд нь хүргээд хаясан билээ. Энэ тухай чимээгүй байхаас өөр аргагүй, аргаа барвал Мопассан руу эргүүлнэ, Мопассаныг мань хүүхэн арав, арван нэгтэйгээсээ уншиж эхэлсэн юм чинь.

Байрны хамгийн жижигхэн тасалгаа хоолны өрөө байсанд Вика гайхаж хоцров. Староконюшений хөндлөн гудамны тэдний байранд бол Москвагийн аливаа байр лугаа адил хамгийн том тасалгааг хоолны өрөө болгодог билээ.

Унтлагын өрөө хүрэх гудааны зөв талаар таазанд тулсан давхар шүүгээ, солгой талд угаалга, халуун усны цэлгэр гэхээр өрөө, бие засах газар байна.

Вика хаалга нээж, лут өргөн модон ор байхыг үзээд,

-Бид нар чинь энэ орон дээрээс бие биенээ олох юм уу? гэж инээд алдав.

-Олно оо, олно гэж Шарль өгүүлэв.

Вика хаалгатай толь, татуурга нь зэс бариултай улаан суман модон шүүгээ энэ тэр рүү хараа шидэв. Элдэв аахир шаахир юм алга, ганцхан цэнхэр шаазан ваар... Хоёр сандал тавивал зүгээр байж магадгүй, бодох хэрэгтэй...

-C'est tout... Ca te plait? * гэж Шарль асуув.

Тэрээр зөвхөн Викагийн ойлгодог үг хэллэгийг францаар хэлдэг билээ.

Вика түүнийг хоёр гараар хүзүүдэн авлаа:

-Ой, Шарль!

Гуравдах юм уу, дөрөв дэх өдөр дээрээ нөгөө Кежмагаас Саша-тай цуг ирсэн хүүхэдтэй хүүхэн буудал дээр үзэгддэг юм байна. Алчуур нь өрөөсөн тийшээ унжчихсан Тэрээр нэг гартаа чемодан цүнх хоёроо барьж, нөгөө гараараа бага охиноо тэвэрчээ. Том охин нь нэг боодолтой юм барьчихсан ээжээсээ хоцорч алдан байна.

Хүүхэн буудлын байшин руу чихэлдэн орж, учир нь олдохгүй бужигнасан амьтдыг бэргэж хургасан харцаар эргүүлдэн харсан ч, хаана түр хоргодохоо мэдэхгүй хулмаганан зогсоно.

Хэдэн өдөр хаа байсан юм бол? Танилынх нь толгой хоргодуулж, тасалбар энэ тэрийг нь хөөцөлдөөд бүтээгүй байх. Олон хонуула-хаасаа айгаад, хоёр хүүхдийг нь ч авч үлдэлгүй явуулчихаж. Эс тийм

бол орой болох гэж байхад юу гэж хүүхдээ дагуулан наашаа ирэхэв.

Саша хүүхэн рүү очив.

-Сайн байна уу, та.

Хүүхэн овсхийн цочсоноо түүнийг танив бололтой мэдэгдэм төдий толгой дохив.

-Аль вэ, би туслая.

Тэрээр чемодан, охины барьж явсан боодолтой юм энэ тэрийг авч, тэднийг дагуулан дотогшилж, хананы тэндэх нэг зайнд чемоданыг нь тавьж дээр нь хоёр охиныг суулгаад бусад юмыг хажууд нь байрлуулав.

* Ингээд гүйцлээ... Чамд таалагдаж байна уу?

-Чемоданд чинь няцрах, хагарах юм байхгүй биз дээ?

Хүүхэн асуултыг сонсоогүй мэт юу ч дуугарсангүй, Саша руу чимээгүй гайхасхийн харж байснаа, оочерын зүг түүний араас дуугүй дагав. Оочерын сүүлд өндөр шар хүн байв.

-За ингээд энэ хүний ард оочерло. Хүүхдүүд рүүгээ очиж жаахан суусан ч энэ хүн хаанаас ч харагдана.

Хүүхэн ойлгож толгой дохив. Тэгээд шал руу гөлөрчихөв. Сашад талархал ч хэлсэнгүй, тасалбар авахад хэр удаан зогсохыг ч асуусангүй. Ийм байдалтай байгаа хүн үгээ эвлүүлж ярих нь юу л бол гэж санаад мань хүн ч хүүхнээс юм хум асуусангүй.

Дараа нь хоёр хүүхэд юм ууна гэж сандаргахад, эх нь ус хаанаас авахыг мэдэхгүй учир Саша данхыг нь авч буцласан усанд явж ирэв. Дараа нь хүүхэн охидоо өртөөнөөс холгүй буй бохир модон жорлон руу аваачин бие засуулахад Саша чемоданыг нь харж өгөв. Маргааш өглөө нь хүүхэн талх сүү авахаар зах руу явахад Саша хоёр охинтой нь үлдэв.

-Бидэнтэй юм идэх үү?

-Би юм идчихсэн... хэмээн инээмсэглэсэнээ, -Гагцхүү таныг “иргэн” гэх үү, “нөхөр” гэх үү гэдгээ мэдэхгүй байна гэж тоглосхийн өгүүлэв.

Хүүхэн түүн рүү эмээсэн байдалтай харж байснаа,

-Намайг Ксения гэдэг гэж дурамжхан хэлэв.

-За тэгвэл танилцлаа, миний нэр Саша.

Урам сэргээх өөр нэг алиа юм хэлэх гэсэн боловч юу ч бодож олж амжсангүй.

Ксения түүний мөрөн дээгүүр айдас хурсан нүдээ бүлтийлгэн харж байснаа талхаа алдчихав. Саша түүний яагаад айсныг эргэж харангуут ойлголоо. Хэдхэн алхмын цаана нэг эргүүл хүмүүсийн бичиг баримт шалгаж явна.

Ксения хана руу улдан ухарч, чемоданаа барьж авснаа хүүхдүүдээ нэг харж, эргүүлийг нэг харж, хаалга руу нэг харж байх нь ухаан солиоров уу гэлтэй Сашад санагдав.

-Битгий зов, тайван зогсож бай гэж Саша түүнд аяархан хэлэв.

Эргүүл Сашагийн паспортыг задлаж үзэлгүй, өөрийг нь гараараа холдуулаад Ксения руу зүглэв. Шинэ хүн гэдгийг өлөн нүдээрээ шууд мэджээ.

-Эмэгтэй, бичиг баримт аа!

Чичирсэн гараараа пальтон дотроосоо паспортоо гаргаж өгөв.

Эргүүл паспортыг үзэж, хэдэн хуудас эргүүлснээ охид руу зааж,

-хэний хүүхдүүд вэ? гэв.

-Минийх.

-Яагаад паспортад чинь бичигдээгүй байгаа юм?

-Эцгийнхээ паспортад бичигдсэн байгаа.

-Хаашаа явж байна?

-Красноярск руу.

Эргүүл паспортыг нь буцааж өгөөд нөгөө нөхрийнхөө араас явлаа. Ксения боодолтой юман дээрээ лагхийн сууж, хоёр гараараа толгойгоо базав.

Саша тамхи татахаар буудлын тавцан руу гарав.

Нөгөө цөмөрхий шүдэт бас л цагаан хоолойны хавьд эргэлдэж харагдана. Сашаг нэгэнтээ харсан боловч юм ярихаасаа айв бололтой.

Гол яллагч Вышинскийн үгийг нэвтрүүлж байлаа.

Цөмөрхий шүдэт бүртгэнэж саад болоод, Саша санаа нь ч олигтой төвлөрч өгдөггүй, ер нь тогтож сонссонгүй.

Буудлын байшин руу эргэж орох хүсэл алга. Хөөрхий муу Ксенийг харахаас өр зурах шиг болно. Бас нэг юм санаа зовоогоод байгаа: Тайшетэд тав хоног гиюүрч байна, хэрвээ эргүүлүүд солигдчихвол шинэ хүмүүс нөгөө хадам эхийн тухай домгийг нь итгэхгүй бол яана? Тэгвэл паспортыг нь хурааж аваад комендантын газар аваачна, тэндээс гарна гэж санасны гарз.

Саша томилолтынхон туслаж магад хэмээн тэнд оочерлож байгаа хүмүүсийг ажиглана. Томилолтын нэг үнэмлэхээр хоёр тасалбар өгөхгүйг ойлгож байгаа ч өөр аргагүйн эрхээр түүгээр үе үе эргэлдэн байв. Юмыг яаж мэдэх вэ!

Зургаадахь өдрийнхөө өглөө тасалбар түгээврийн тэнд гурван хөгжилтэй, шижгэр залуу цонх тогшлон зогсож байхыг хараад геологчид уу, хайгуулчид уу гэх бодол толгойд нь зурсхийв. Уул нь нэгдүгээр сард Сибирыт юуных нь хайгуулчид, юуных нь геологчид байх вэ дээ? Комсомолын ажилтнууд юм болов уу? Саша тэднийг сайн ажиглав. Адилхан оготор дээлтэй, эсгий гуталтай, үстэй малгайтай, гурвуулаа үүргэвч үүрчихэж. Комсомолын ажилтантай төсгүй юм аа. Саша цонх руу зүтгэлж, тэр гурвын дэргэд очиж зогсов. Үг яриа, тоглоом наргианаас нь үзвэл тэд москвагийнхан байсанд Саша бүр баярлацихав. Бас хайгуулчид гэж зөв таасандаа баярлав.

Нэг нь зөв царайтай, шувган мөртэй өндөр залуу аж. Тэр залуу аль нэг байдлаараа Василий ламтантай төстэй, тэгээд ч тэр үү, Сашад нэг л дотно санагдаад явчихав. Цаад хоёр нь түүнийг Олежка гээд байхыг үзэхүл Олег нэртэй байх нь. Зөвхөн нуруугаар ялгарах биш, хамгийн шаргуу нь, бас тэдний ахлагч нь бололтой.

Тасалбарын өрөөнөөс өртөөний дарга гарч ирэхэд Олег шууд түүн рүү хандлаа.

-Бид нар чинь хэзээ тасалбартай болох улс вэ?! Төмөр замын ардын комиссариатын даалгавар биелүүлж явна гэж би танд хэлсэн шүү дээ.

-Замын комиссариатаас яваа бол хөнгөлөлтийн үнэмлэх байх ёстой.

-Манай хүрээлэн Замын ардын комиссариатын захиалгаар хайгуулын ажил хийж байгааг би танд хэд тайлбарлах юм бэ. Усть-Кут руу зам салаалах гэж төсөл хийж байгааг та мэднэ биз дээ, эсвэл мэдэхгүй юм уу?

-Бүгдийг нь мэдэж байгаа, гэхдээ суудал нь байхгүй. Суудал гарахаар явцгаагаарай гэж өртөөний дарга догирхов.

-Бид Москва руу цахилгаан явуулна гэж Олег сүрдүүлэв.

-Бурхан тэнгэртээ явуулсан ч суудал нь байхгүй. Эрхүү бидэнд суудал өгөхгүй байна.

-Та замын зураг төсөл хийх ажлыг саатуулж байна гэж Олежка ширүүлэв.

-Айлгах хэрэггүй! Би өөрөө та нарыг үүрч явж чадахгүй. Битгий шуугиад бай.

Тэгж хэлчихээд яваад өгөв.

-Суудал нь байхгүй, тасалбар нь байхгүй, вагон нь байхгүй хэмээн Саша яриа өдөх санаатай инээв.

-Мал! Биднийг хоёрдахь өдрөө зовоож байна гэж Олежка зүхэв.

-Хоёрдахь хэмээн Саша түүнийг давган өгүүлснээ, -Би явж чадахгүй зургаа хонох нь гэв.

Яриа өрнөөд ирэв. Тэр гурав нэг зураг төслийн хүрээлэнд ажилладаг юм байж. Товчилсон нэрнийх нь учрыг Саша олсонгүй. Тайшет-Усть-Кутын чиглэлд тавих төмөр замын зураг төслийн даалгавар зохиож байгаа аж. Зун нь хөдөөгүүр хайгуулын ажлаа хийж, Тайшетэд отог дээрээ ирээд, боловсруулах ажил нь удаашран сая нэг юм дуусч, материалаа аваад Москва руу харьцгаах гэж байгаа энэ гэнэ. Олежка нь бүр Арбатынх болж таарав. Большой Афанасьевскийн хөндлөн гудманд байртай, Староконюшений гудамны 9 дүгээр сургуульд сурч байсан аж.

-Би тэр сургуулийг чинь мэднэ, хуучин Медведниковынх гэдэг байсан. Бид гимнастикийн танхимд нь очдог байсан юм. Би бас Арбатынх, 51 дүгээр байшингийнх, “Арбатский Арс” кинотеатр байдаг шүү дээ, мэдэх үү? гэж Саша асуув.

Олежка кинотеатр төдийгүй, Сашагийн байшинг мэддэг, тэнд найз нар нь бий, жишээлбэл, Мелик Парсаданов гэж бий гэнэ.

-Гриша юу?

-Харин тийм!

-Тэгвэл тэр бид нар чинь нэг орцных. түүний дүү Ритатай... Ритаг мэдэх үү?

-Мэдэлгүй яхав!

-Би түүнтэй нэг ангид сурч байсан.

-За тийм байж, чамтай энд таарсан нь аятайхан байна шүү гээд Олег инээмсэглэв.

түүний нөхөрсөг харьцаа Сашагийн урмыг сэргээлээ.

-Хөөе, залуус аа, надад томилолтын үнэмлэх байхгүй, та нар туслаж үзээч гэж Саша аяархан

гуйв.

-Чи яаж яваад энд ирчихсэн юм бэ?

-Зүрх сэтгэлийн явдлаар хэмээн Саша аргалав.

-Бид гурав дундаа нэг үнэмлэхтэй гээд Олежка бодлогошров.

-Тасалбарын хүүхэн томилолтын үнэмлэх харах юм уу? гэж шөнтгөр хамартай, өтгөн цайвар үстэй, яагаад ч юм бэ, Вартанян гэх армян овогтой нөгөө нэг залуу нь зөрөв.

-Харна гэж Олег хэлэв.

-Бидний үнэмлэхийг гараар бичсэн юм чинь чи энүүнийг нэмээд биччих.

Тэд нар оочерын бусад хүнд дуулдахааргүй аяархан ярьцгааж байгаа билээ.

Олежка халааснаасаа үнэмлэхээ гаргаж ирэв. Албан хуудсан дээр ёсчлон дарсан тамгатай хэрнээ үнэхээр гараар биччихсэн байжээ.

-Яг энд оруулаад биччих гэж Вартанян хэлэв.

-Москванд очихоороо яахав?

-Москванд очоод дарчихна, өөр хэн нэгнийг явуулах гэж байснаа больчихоод дарчихсан юм гэж хэлэхгүй юү.

-Харин ийм бэх хаанаас олох вэ?

Ээ, тэнгэр минь бэхнээс болж бүх юм бүтэлгүйтэх нь үү? Ердийн сурагч бэх шүү, гэхдээ энэ өртөөн дээрээс хаанаас олох вэ?

-Тасалбарын хүнд бэх байгаа юм биш биз, түүнээс гуйвал болохгүй юу? гэж Саша сэтгэл зовсноо нууж ядан өгүүлэв.

Өртөөний дарга дахиад хүрээд ирэв. Дэргэдүүр өнгөрөхдөө,

-Красноярск хүртэл явах уу? Тэндээс Москва руу шууд галт тэрэгтэй гэж Олегаас асуув.

-Явцгаана шүү.

-Аль вэ, томилолт оо.

Олег үнэмлэхээ өглөө. Дарга түүнийг хаалганы хатавчин дээр барьснаа залуус руу дурамжхан харж,

-Та нар хэдүүлээ юм бэ? гэж асуув.

-Дөрвүүлээ гэж Олег хариулав.

Өртөөний дарга үнэмлэхний булан дээр 116-4 гэж цохлоо.

Эхнийх нь галт тэрэгний дугаар, дараачийнх нь тасалбарын тоо.

Энэ ч ёстой том аз шүү. Красноярск-Москва гэсэн галт тэрэг тэндээс явж байгаа, суудал олоход хамаагүй хялбар, аргаа барвал Новосибирск, эсвэл бүр Свердловск хүрсэн ч яахав, тэндээс Москва руу өдөр бүр галт тэрэг явна.

Саша тасалбарын мөнгөө өгөх гэтэл Олег,

-Галт тэргэнд тооцоогоо хийцгээе. 116 дугаар галт тэрэг хоёр цагийн дараа ирнэ гээд авсангүй.

-За, та нарт баярлалаа хэмээн Саша Олег, Вартанян хоёр руу харав.

-Тасалбараа авсан хойно л баярласнаа хэлээрэй.

Гуравдах залуу нь ярианд оролцсонгүй. Саша зүрх сэтгэлийн явдлын тухай ярихад үнэмшихгүй жогтой инээмсэглэсэн хэдий ч тасалбар авч өгөхийг эсэргүүцээгүй. Тэрээр үүд рүү хараад Вышинскийн үгийг сонсож байв.

“... Энэ бол тагнуул, алан хядагч, хорлон сүйтгэгчдийн балмад бүлэг.. Төмөр замын зам төмрийг салгаж аваад галт тэрэг онхолдуулах... уурхайг хорт хийгээр дүүргээд... хэдэн арван уурхайчинг тийш нь оруулах... завод галдан шатаах... хүүхдүүдийг нүхэнд хийж байгаад дэлбэлэх... энэ тэр бол эдгээр “улс төрийн” зүтгэлтнүүдэд юу ч биш.

... Гагцхүү буудан алвал таарах энэ нүгэлт гэмт хэрэгтнүүдийг би бүх ард түмэнтэйгээ хамт яллаж байна!”

Саша гурван залуугийн тэнд хэсэг зогссоноо, Ксенийн юмтай хамт тавьсан чемоданаа авахаар тийшлэв.

-Би гарах санаатай таныг харж байсан юм, манай хоёрыг харзнаж байна уу гэж Ксения гуйв.

-Та удахгүй биз дээ?

-Арван минут, тэрнээс удахгүй.

-Яв, яв.

Хоёр охин бие биенээ налаад чимээгүй томоотой сууцгааж байна. Саша тэр хоёрыг бүр өрөвдчихөв. Эцгийнхээ баривчлагдсаныг тэд яаж мэдэхэв, гэхдээ ээжийнхээ түгшүүрийг харж байгаа, ямар нэг юм болсныг ойлгож байгаа.

Саша томынх нь хацрыг илбэн,

-Чиний нэр хэн бэ? гэж асуулаа.

-Лена.

-Лена, Елена, хөөрхөн Елена. Тийм үлгэр мэдэх үү?

-Миний нэр Елена биш Марлена.

-Ө-өө, ойлгомжтой, “Маркс-Ленин” байх нь. Чинийх бол? гэж багаас нь асуув.

Цаадах нь нэг ойлгомжгүй юм шулганав.

-Юу гэнэ ээ, юу гэнэ ээ гэж Саша дахин асуув.

-Энүүний нэр Лина, Сталин гэсэн үг гэж том нь тайлбарлав.

Тэднийх ямар айл болохыг хоёр охины нэр бараг хэлж өгч байна.

Саша Линаг өхөөрдөн хацрыг нь илбэтэл танхимд сүүрс алдах мэт чимээ гарч, чихэлдсэн хүмүүс сандран хуйлрах шиг болохуйд, эргүүл явж байна гэдгийг мань хүн мэдрэв.

Эргүүлийн хоёр Саша руу ирлээ. Цаадуул нь солигдоогүй болохоор Саша паспортаа хэнэггүй, сурмаг гаргаж өгөв.

Эргүүлийн ахлагч ч паспортыг нь авч зэрвэс харснаа тэр дор нь буцааж өгөөд хүүхдүүд рүү дохиж,

-хэний хүүхдүүд вэ? гэж асуув.

-Нэг хүүхнийх, түр гадагшаа гарсан.

-Ямар хүүхэн, овог нь хэн бэ?

-Мэдэхгүй, энд зогсож байсан нэг хүүхэн л, “түр гарчихаад ирье, хүүхдүүд харзнаж байгаарай” гээд гарсан.

Ахлагч Ленагийн өмнө явган сууж,

-За охин, нэр чинь хэн бэ? гэж асуув.

-Марлена.

-Сайн байна, Марлена! Тэгвэл овог чинь хэн бэ, мэдэх үү?

-Мэднэ. Павлова.

-Па-авлова хэмээн эргүүл сэтгэл амарсан янзтай сунжруулан хэлснээ, -Павлова гэнэ ээ гээд нөгөөдөхтэйгөө нүд ирмэлцэв.

Тэгэхээр яг Ксенийг хайж байсан байх нь. Мөн түргэн, мөн амархан олов оо. Хүүхэн явчихаж амжсангүй.

Эргүүл дахин Ленад хандаж,

-За сайн байна, харин ээж чинь хаа байна? гэж асуув.

-Энд байгаа, дөнгөж сая гарсан.

-Тэгвэл аав нь?

-Аав... гэснээ охин, яагаад ч юм бэ, Саша руу харав. -Аав Красноярск явсан.

-Та нар аав руугаа явж байх нь ээ дээ?

Охин дуугарсангүй.

Эргүүлийн хоёр тэдний дэргэдээс цаашилсан боловч охидыг хараанаасаа гаргахгүй байв. Бас үүд рүү харуулдаж байгаа нь илт. Тэгээд Ксенийг буцаж ирэнгүүт хоёр эргүүл түүн рүү зүглэв. Одоо энэ зовлонт хүүхнийг барьж саатуулаад, комендантын газар руу аваачна. Ингэнэ гэдэгт Саша өчүүхэн ч эргэлзсэнгүй. Ээ, хөөрхий зайлуул...

Саша чемоданаа аваад тасалбарын цонхны тэнд зогссоор байгаа нөгөө гурав руу очих гэснээ болив. мань хүн ч эргүүлийнхний хараанд байгаа юм чинь гэнэтхэн юмаа аваад явчихвал Ксенийн танил, эсвэл нөхрийнх нь танил, тэгээд цуг явж байна гэсэн сэжиг төрүүлж магадгүй, тийм учраас эргэн тойронд буй энэ олон хүн шиг мөрөөрөө хэнэггүй царайлан зогсож байсан нь дээр. Ерөөсөө тэр гурав руу ч очиж болохгүй, яг тэд нартай явах нь гэсэн

сэжиг авахуулчихаж мэднэ.

Энэ хооронд эргүүлүүд Ксения руу хүрээд ирлээ.

-Бичиг баримт аа!

түүний паспортыг хоёр ч удаа шалгасан болохоор Ксения түрүүчийнхээсээ хавьгүй тайван харагдана.

Пальтоныхоо дотроос паспортаа дахин гаргаж ирэв.

Эргүүл паспортны хуудаснуудыг хэдэнтээ эргүүлж, зургийг нь өөртэй нь тулган, хүүхэн рүү нэлээн удаан харж байснаа паспортыг нь буцааж өгөлгүй,

-Эмэгтэй, комендантын газар руу очъё! гэж тушаав.

-Үгүй, үгүй... Яах юм бэ? Би хүүхэдтэй... гэж хүүхэн дуу алдав.

-Хүүхдүүд хүлээзнэг, та одоохон буцаад ирнэ.

Охидууд уйлалдан ээжээсээ зуурлаа.

-Эмэгтэй, явья! гэж эргүүл бүр ширүүлэв.

Ксенийг аваад явчихлаа. Үүдэнд очоод охид руугаа дахин нэг эргэж харав. Нүүр нь нуль нулимас.

Саша хоёр охиныг тэврэн аргадав. Золгүй хоёр нялх амьтан гар дор нь мэгшин овгононо.

-За, хүүхдүүд ээ, больцгоо! Ээж нь тасалбар авахаар явсан. Тасалбараа авчихаад хүрээд ирнэ, тэгээд л та нар яваад өгнө.

Саша хэдийгээр хүүхнийг тэндээс тавихгүй, комендантын газраас хэн нэгэн ирж хоёр охиныг юм хумтай нь аваад явна гэж итгэж байвч охидыг ийнхүү тайвшруулах гэж оролджээ.

Гэтэл хэн ч ирдэггүй.

Саша цухалдаж эхлэв. Нэмэрт нь яллагдагсадын эцсийн үгийг радиогоор нэвтрүүлж байгаа нь таарав. Пятаковын нэр сонсогдлоо. Саша энэ хүний нэрийг Иван Григорьевич, Марк энэ тэртэй холбож боддог билээ.

Марк түүнээс няцаж, толгойноосоо хөсөр таягдан хаясныг Саша ээжийнхээ захидлуудаас ойлгосон билээ. Нагац ахынх нь тухай хүний урманд ганц ч удаа, ганц үгээр ч болохноо дурсаагүй. Уул нь Саша түүнд ааваасаа илүү шахуу хайртай байсан болохоор нэг үе хэрхэндээ шарлахсан, гэвч яая гэхэв, эцсийн бүлэгт энэ нь ч эдгэсэн болой. Гагцхүү Иван Григорьевич, Марк энэ тэр Пятаковын хоморгонд л битгий орчихоосой!

Пятаков тулгасан ялыг зөв хэмээн хүлээн зөвшөөрчээ:

“Би өдүүлсэн ялт хэргээ маш хурц ухамсарлаж байна, тийм учраас та бүхнээс уучлал эрж чадахгүй. Тэр ч бүү хэл, та бүхнээс өршөөл гуйж ч зүрхлэхгүй байна.

Хэдэн цагийн дараа та нар ялын шийдвэрээ гаргана. Тэгвэл би хийсэн гэмт хэрэгтээ няцлуулж, хар толгойныхоо буруугаар хамаг юмнаасаа хагацаж, нам ч үгүй, анд нөхөд ч үгүй, ар гэр ч үгүй болчихоод, өөрийгөө хүртэл үрэн таран хийчихээд та нарын өмнө бузар буртагт шигдчихээд зогсож байна...”

Дараа нь Радекийн ээлж болов:

-“Иргэн шүүгч нар аа! Би эх орноосоо урваснаа нэгэнт хүлээс-нээс хойш өөрийгөө өмгөөлж ямар нэг юм хэлэх учир байхгүй...”

Цагаан хоолой паржигнаад хаа нэг салангид үгнээс өөр юм ялгарч сонсдохоо болив. Саша Радекийн үгийг сонсмоор байсан учраас дэмий л амандаа зүхэв.

-“...Троцкийгээс захиа, удирдамж авч байсан, харамсалтай нь, тэдгээрийг шатаачихсан... Бид нар, тухайлбал, би өөрөө, өчүүхэн боловч өршөөл уучлал шаардаж чадахгүй юм...”

Шестов:

-Би ганцхан юм хүсч байна... Цаазын тавцан дээр гарч эх орноосоо урвагчийн бузар толбыг цусаараа угааж арилгахыг л хүсч байна”.

Сонсоход ч аймшигтай! Тэгвэл тэдний авгай хүүхэд, ойр дотныхонд нь одоо ямар байгаа бол? Шестов... Шестов... Байцаалт дээр тэр юу ярьж байлаа? Энэ хэдэн өдөр радио хичнээн ч хүний нэр хэлэв, улайсан хүлээсэн ямар ямар аймаар хэргийн тухай мэдээлэв, толгойд бөөн бантан. Үгүй ээ, саналаа! Шестовын заавраар Прокопьевскт бил үү дээ, динамитны нууц агуулах барьсан. Уурхайчдын хүүхдүүд тэр агуулахаас холгүй тоглож байгаад, газраас жаахан оглосон чинь динамит дэлбэрч бүгд амь үрэгдсэн гэж байгаа. Энэ бол 1934 онд болсон хэрэг. Саша үүнийг сонсоод нүд нь орой дээрээ гарчээ. мань хүнийг сургуулийн ханын сонинд тайлбар шүлэг бичсэн төдийд зүйл анги өгсөн хэрнээ динамитны агуулах байгуулсан, олон хүүхдийн амь насыг бүрэлгэсэн Шестов зүв зүгээр өнгөрсөн байж. Түүгээр зогсохгүй Шестов Кузнецкийн сав газрын уурхайнуу-дад таван жилийн турш хорлон сүйтгэх ажил хийж байсан, тийм хэрэгт хүмүүсийг элсүүлж байсан, аллага зохион байгуулж байсан, алан хядагчдын болон хорлон сүйтгэгчдийн бүлгүүдийг сан-хүүжүүлэх зорилгоор банк дээрэмдэхэд оролцож байсан энэ тэрээ нэгд нэгэнгүй хүлээсэн. Тэгвэл ДЯАК энэ тухай ажиг сэжиг ч үгүй байсан болох нь уу? Залуус та нар банкаа дээрэмдэж, хүн амьтнаа алж л бай, бид дуг хийж байя гэсэн байх нь уу?.. хэнийг хуурцгааж байна вэ?

Бүгд шал худлаа, бүгд зохиомол зүйл.

Цөмөөрөө хэргээ хүлээчихэж байгаа юм! Өөрийнхөө гараар энэ төр улсыг байгуулсан гэж болох, хэдхэн сарын өмнө нэр ус нь цууриатаж байсан домогт намтартай хүмүүс тулгасан

ялыг зөв зүйтэй хэмээн нотлож, улс орноо ангал руу түлхэж байснаа хүлээсэн байгаа юм.

Харин энэ шүүн таслах ажиллагаанд хий гараад байгааг ганц Радек л цаагуураа хэлэх шиг Сашад санагджээ.

Троцкийн захиаг, харамсалтай нь шатаачихсан. Тэгэхээр хэргийн материалд хавсаргаагүй байх нь ээ дээ? Тэгвэл асуулт гарна шүү дээ: Тэр захианууд нь ерөөсөө байсан юм уу, Троцкий захиа бичсэн юм уу?

Захидал энэ тэр гэдэг чинь шал худлаа. Шестов ч Берлинд Троцкийн хоёр захидлыг Седовоос Москвад хүргэхээр авсан гэж мэдүүлсэн шүү дээ. Шаахайд нууж авчирсан гэсэн. Нэг нь Пятаковг, нөгөө нь Мураловг зориулсан захиа. Тэр захианууд хаачив?

Өнгөрсөн наймдугаар сард, Саша нөгөө Мозговадаа “Нэгдсэн төв”-ийг шүүсэн материалыг дахин дахин уншиж байхдаа, Зиновьев, Каменев хоёрын оронд шүүх хуралд будмал жүжигчид оруулсан гэж бат итгэж байсан. Эсвэл яллагдагсадад ямар нэг эм тариагаар нөлөөлсөн, үгүй бол тэднийг ховдсон ч байж магадгүй. Гэтэл Иван Никитич Смирнов тэдний тэр жүжгийг нураасан шүү дээ.

Тэгвэл юу байх вэ, эрүү шүүлт үү? Дьяков өөрт нь эрүү шүүлт тулгаагүй. Ер нь ч эрүү шүүлт гэдэг чинь дундад эртний явдал. Одоо цагт хүнийг ул тавхайнаас нь шарах, өвдөгний нүднийх нь доогуур шаантаг шаах, хөлөөс нь дүүжилж байгаад толгой дор нь гал түлэх, эсвэл нүцгэн нуруугаар нь хадаастай гулуузаар арьс махыг нь туузлан шударч “цацагт туулай” хийх энэ тэрийн тухай бодохуйяа аймшигтай. Үгүй ээ, мөрдөн байцаагчийн өрөөнд гал яаж түлэхэв, тийм учраас эдүгээ тавхайг нь шарна гэж байхгүй, “цацагт туулай” ч хийх нь юу л бол, шүүх хуралд эрэмдэг хүн оруулалтай нь биш. Бодвол аминаас наахнуур л балбаж занчдаг байх. хэн ч тэсэхээргүй занчдаг байх. Тэгээд л өөрснийхөө тухай ч, бусдын тухай ч худал мэдүүлдэг хэрэг...

Саша цагаа харлаа. Ээ, чөтгөр чамайг! Ксенийг авч явсаар бараг цаг болж байхад охидыг авах гэж хэн ч ирсэнгүй. түүнийг тавих учраас ингэж удаж байгаа юм болов уу? Түрүүчийн өдрүүдэд эндээс хүн аваад явсан бол тэгсхийгээд л ирж юмыг нь авдаг байсан даа! 116 дугаар галт тэрэг удахгүй ирнэ, тэр болтол Ксения ирэхгүй бол яадаг билээ?

Охидыг өөрөө комендант руу хүргэж өгөх үү? Эхийг нь авсан, май, хүүхдүүдийг нь ч ав! Тэгтэл нөгөөдүүл чинь, “Чамд ямар хамаа байна? Юу гээд бусдын хэрэгт оролцоод байгаа юм? Хүүхэд эхтэй гэдгийг чамтай чамгүй мэднэ. Чи яахаараа хөөцөлдөж яваа юм? Чи түүний юу нь вэ? хэн нь юм бэ? Бичиг баримтаа үзүүл! А-хаан, Кежмад цөллөгт байсан юм уу, тэгээд Павловынхныг мэддэг байх нь. Тийм учраас санаа тавьж байх нь. Тэр муу ардын дайсан Павлов ийм хүнтэй-цөлөгдсөн эсэргүүтэй холбоотой байсан байх нь, тэр л чамайг суллаж л дээ, ойлгомжтой! Чамайг бузар муу явдлаа дахиг гэж суллаж! Энэ муу нохойн гөлгийг барьж ав! Яасан мундаг өмгөөлөгч вэ!” За тэгээд, эхлээд “хэн болохыг нь тодруулах” гэж нэг тийш нь шүүрдчихнэ, дараа нь ялын шинэ хугацаа наачихна.

мань хүн цагаан хоолойгоор тасралтгүй үргэлжилж буй орь дуунаас айсандаа болоод, нөгөө цасан дээр өвдөг сөхрөн суусан хоригдлуудыг үзсэндээ болоод юмыг арай даваадуулж байж

мэднэ. Магадгүй. Тэглээ ч гэсэн комендантын газар руу очих нь дэндүү аз сорих хэрэг.

Гэтэл залуучууд түүнд тасалбар авчихаад байхад хоёр охины араас хүн ирэхгүй бол яах вэ? Саша тэднийг чемодан дээр нь суулга-чихсан, мань хоёр бие биенээ налаад зүүрмэглэж байна. Энд нь үлдээх үү? Ямар ч байсан эднийг авах ёстой, авах үүрэгтэй. Эхийг нь баривчилчихаад нялх хүүхдүүдийг зөнд нь хаяж таарахгүй! Зүгээр ч үгүй, галт тэрэгний буудал дээр шүү!

Саша улам цухалдан, тасалбар түгээврийн зүг байн байн харж зогсов. Галт тэрэг нь хоцорчихоосой, яршиг зүгээр!

Цагаа харвал 116 дугаар галт тэрэг иртэл арван таван минут үлджээ. Тэгтэл ч түгээврийг тэнд улс хөдлөөд эхлэлээ. Тасалбарын хүн ирсэн бололтой, энэ бол галт тэрэг цагтаа ирэхийн шинж. Хүмүүс цонх руу овоорч бөөгнөрөөд нөгөө гурвын бараа ч тасрав.

Одоо мань хүн буудлын дэргэдэх комендантын газрын зүгээс хараа салгахаа болив. Тэр зуураа радиогоор ял зарлан сонсож буй нэвтрүүлэгчийн үгийг чагналаа.

“Юрий Леонидович Пятаков, Леонид Петрович Серебряков нарыг эрүүгийн хуулийн дээд хэмжээгээр яллаж, буудан алах.

Муралов, Дробнис, Лифшиц, Богуславский, Князев, Ратайчак, Норкин, Шестов, Турок, Пушкин, Граше нарыг буудан алах.

Сокольников, Радек нарыг арван жилээр...”

Ялын сүүлийн хэсэг Сашагийн чихэнд өртсөнгүй. Юун гэвэл, комендантын газраас дөрвөн цэргийн хүн гарч хоёр нь тасалбар түгээвэр рүү эргэж, хоёр нь тэдэн рүү зүглэжээ. За, ашгүй дээ. Үгүй ээ, нөгөө хоёр чинь хажуугаар нь өнгөрөөд явчихлаа. Энэ хоёр хүүхдийг арай мартчихаагүй байгаа даа?

Ер нь түгээвэр онгойх бүрт Сашагийн оочер ч бас хөдлөөд эхлэнэ. Гэхдээ хорогдоно гэж байхгүй, түр гарсан өөр газар сууж байсан энэ тэр хүмүүс ирж, оочер харин ч уртсана. хэн хаана зогсож байснаа сураглаж, баахан маргалдана. Тэгээд таван минут өнгөрч тасалбарын цонх хаагдмагц, оочер дахин тайвширч, улсууд дахиад л

горь тасартал хүлээхээр байсан байсан газар руугаа тарцгаана.

Энэ удаа ч бас яг тэглээ. Гэхдээ түгээвэр урьдынхаас арай удаан онгойж, нийтийн оочерын эхний хэдэн хүнд хүртэл тасалбар олдов. Тэгэхээр томилолтынхон тасалбар авсан нь тодорхой.

Саша дөнгөж ингэж бодтол Вартанян тасалбараараа даллан түүн рүү зүтгэлж яваа нь харагдав:

-Аль вэ, бушуулаарай! Нөгөө хоёр маань түрүүлээд гүйчихсэн.

-Хэддүгээр вагон бэ?

-Тав. Бушуул гэж Вартанян яаран хариулав.

Охидууд нүдээ нээж, бага нь дахиад уйлагнав.

-Дуугай бай, Лина дуугай бай.

-Энэ хоёр чинь чинийх үү? хэмээн Вартанян нүд нь бүлтийв.

-Биш ээ, биш, хүний хүүхдүүд, гэхдээ эдний аяыг олохгүй бол болохгүй гэж Саша цөхөрсөн дуугаар өчив.

-Түргэхэн аяыг нь ол, битгий уллаад бай!

Тэгээд таваргаж одов.

Яах вэ?! Ингээд балрах нь. Яасан заяагүй тавилан бэ! Энэ галт тэргээр л явахгүй бол эндээ үүрд үлдэнэ. Гэхдээ яахав? Охидыг аваад явах уу? Инээдтэй, тэнэг юм болно. Эднийг авах гэж, хүүхний юм хумыг авах гэж заавал ирэх ёстой. Улс орон даяар баривчилгаа явагдаж, эцэг эхчүүдийг шоронд хийж байна, хүүхдүүдийг нь эрхбиш нэг тийш нь болгодог байлгүй. Энэ хоёрын учрыг ч олох ёстой. Өөрөө энэ хоёртой балралтай нь биш.

Тэрээр арга барагдан ийш тийш харж байтал, холгүй суугаа задгай хар хилэн хантаазтай нэг хүүхэнтэй харц нь мөргөлдөв. Нүдэнд дулаахан ил царайтай, нас тогтсон гэлтэй хүүхэн. Ксенийг авч явахыг бас харсан бол хоёр охиныг өрөвдөж байгаа байлгүй. Саша түүн рүү ухасхийв.

-Хүүхэн гуай, та энэ хоёр охиныг харзнаж байхгүй юу? Би энэ галт тэргэнд суух тасалбартай, хоцрох нь. Та тус бол, тэгэх үү?

-Ээ, хүү минь, чадашгүй, чадашгүй. Битгий гомдоорой.

Ер нь ч мань хүн тэгнэ л гэж бодсон л доо.

-Хөөе, хүүхээ хэмээн сайхь авгай Сашаг тонгой гэж байгаа бололтой хуруугаараа дуудав.

Саша түүн рүү тонгойв. Хүзүүнд нь хэрээсэн сахиусны оосор харагдана.

-Хүү минь, а-аан гэж бай. Чамд хэн ч тус болохгүй. Одоо чинь, бидэнд айхаас өөр юм алга, хүү минь.

За тийм байж. Энэ эгчтэй цагаа шал дэмий үрчихлээ! хүний сайн санаа, өрөвч сэтгэл, нүнжиг, бүх юмыг айдас залгичихаж. Гэхдээ мань хүнд ганц минут ч саатах боломж алга. Өөрт нь бусдаас илүү юм хэрэгтэй юм уу, арай ч дээ?!

Саша чемоданаа авлаа. Хоёр охин түүнийг ширтэнэ.

Үгүй ээ, чөтгөр чамайг, яаж энэ хоёрыг орхих вэ дээ! Яаж хаяж явах вэ! Тэгвэл насаараа өөрийгөө зүхэх хэрэг болно! Бүх насаараа тарчлана! Одоо комендантын газар хүргэж өгье, юу л болвол болно биз!

Харин яаж эднийг гартаа багтаадаг билээ, тэгвэл л арай түргэн очно, чемоданаа үүргэвчээр сольчих минь ч яалаа, арай амар байхгүй юу.

-За, алив, над дээр гараад ир! гэж охидуудад хэлэв. Тэгэнгүүт зогтусав. Нөгөө харуулын хоёр хажуухантайгаас гараад ирлээ. Нэг нь Ксенийн чемодан, боодол хоёрыг авч, нөгөө нь охидуудад,

-За, явцгаая, хүүхдүүд ээ... Явцгаая... Ээждээ очицгоё... гэж хэлэв.

Саша үгийнх нь эцсийг ялгаж сонссонгүй. Олон хүний дундуур бүдчүүлэн зүтгэж, тавцан дээр ухасхийн гарч ирлээ.

Яг урдуур нь хурдаа авч байгаа 116 дугаар галт тэрэгний сүүлчийн вагон жирэлзэн өнгөрөх нь тэр ээ.

Нөхөр Сталины хамгаалалтын албаны дарга Власик шөнөжин түгшүүрлэж хонолоо. Сталины малгай, гутал хоёрыг солих ёстой байж. Энэ бол төвөгтэй бөгөөд хариуцлагатай ажилбар.

Сталин хувцсаа солих дургүй, дассантайгаа яваад байдаг болохоор түүнд тиймэрхүү санал тавьж зүрхлэх хүн эс олдоно. Тэр ч атугай өвлийнхөө хувцаснаас зуныхад, эсвэл зуныхаас өвлийнхөд шилжих ёстой боллоо гэхэд мань хүн ноднингийнхоо өмсөж байсан хувцсыг л шаардана. Өөрт нь тааруулж хувцас оёх, биеийг нь хэмжих, оёсноо өмсгөж үзэх энэ тэрийг хэнд ч эс зөвшөөрнө, ард нь хэн нэгэн хүн бүртгэнэж байхад үнэн голоосоо дургүй. Ямар нэгэн хувцас солих болвол зөвхөн бэлэн хувцсаар солихыг л зөвшөөрнө. Дотуур хувцас, цамц, өмд, кителийн хувьд аргыг нь олдог болсон. Власик Сталины хэмжээг сайн мэднэ. Түүгээр ч барахгүй, бие бялдрын хувьд Сталинтай яг адилхан нэг нөхрийг хамгаалалтын албаныхан дотроос сонгож авчээ. Сталины хуучин кителиэс хэмжээ авч хийчихээд тэр цэрэгт өмсгөж шалгана. Власик харин Сталины гэдсийг маш нарийн ажиглаж, бүсээ аль нүхэнд товчилж, чангалах буюу сулруулдгийг нь тогтооно.

Малгай солих тухайд бас аргалж сурчээ. Сталины хуучин үстэй буюу саравчтай малгайн хэлбэр, дүрс, хэмжээгээр үлгэр авч малгай хийлгээд хуучин малгайных нь хажууд, өлгүүр дээр тавьчихна. Нөхөр Сталин түүнийг нь өмсөж үзээд, тэр чигээрээ яваад өгсөн бол болж байгаа нь тэр, тэр малгайг өмсөнө гэсэн үг. Хэрвээ өмсөж үзчихээд, тайлж хуучнаа барьж авсан бол түүнийг өмсөхгүй гэсэн үг, шинийг дахиж хийхээс өөр арга байхгүй.

Харин урьд шөнө бол малгай төдийгүй савхин гутлыг нь солих хэрэгтэй байсан юм. Мөн лут асуудал шүү! Нөхөр Сталин хуучин гутлаа бүр зан гартал нь элээчихсэн юм. Сталин хавтгай тавхайтай, зүүн хөл нь зургаан хуруутай гэдгийг бодолцон байж, хуучин гутлаар нь үлгэр хийж байгаад шинийг хийлгэнэ. Тэгээд шөнө нь буйдангийн өмнө хуучин гуталтай нь зэрэгцүүлж тавьчихаад, айдаст автан өглөө болохыг хүлээнэ. Власик нойр хулжсан ийм шөнийг шил коньякаар хань хийж байж гэтлэнэ. Нөхөр Сталин өглөө босоод шинэ гутлаа өмсөж, өрөөн дотуураа хэсэг явснаа, толины өмнө очиж, ямар харагдаж байгааг нь харна, тэгээд аятайхан санагдвал өглөөний цай дуудуулна. Харин шинэ гутал нь хөлд нь эвгүй ч юм уу, аль нэг байдлаар нөхөр Сталины сэтгэлд нийцээгүй бол тайлж, хуучнаа өмсөөд, Власикийг дуудуулж нөгөө гутлыг түүний хөл рүү үг дуугүй чулуудна. Власик түүнийг нь хамж аваад зайлна.

Зуны цагт арай хялбар байх нь бий. Нөхөр Сталин зуны цагт зуслан дээр байхдаа заримдаа хөнгөн шаахай өмсдөг тул шинэ гутлыг хуучинтай нь зэрэгцүүлээд тавьчихад нэг их төвөгтэй биш. Харин одоо бол өвөл цаг, нөхөр Сталин буйдан дээр сууж гутлаа тайлаад, яг тэрүүхэнд нь тавьчихна. Нөхөр Сталин их сэргэг унтдаг хүн, шөнө түүн рүү орно гэж байхгүй. Сүр сархийх төдий чимээ гарлаа гэхэд мань хүн дэрэн дороосоо гар буугаа аваад шууд панхийлгэчихнэ... Тэгэхээр Сталиныг жорлонд орохыг хүлээх ганцхан арга бий. мань хүн одоо шөнө босдог болчихоод байгаа юм. Жижүүрийн овсгооноос л бүх юм хамаарна.

Өнөө шөнийн хувьд гутлаа яаж ийгээд оруулаад тавьчихсан. Тэглээ ч Власикийн сэтгэл амарсангүй. Өчигдөр орой Сталин хүн хартай ч ярихгүй, баргар царайлан их уцаар байсан,

өглөөний арван цагт Ежовыг дуудсан гэхээс өөр юу ч хэлээгүй. Ийм эрт дуудсан нь ер бус зүйл. Нөхөр Сталин орой унтаж, орой босдог атал энэ удаа арван хоёр гэхэд орондоо орж, жаахан юм уншиж байгаад яг нэг цагт гэрлээ унтраасан.

Нөхөр Сталин есөн цагт босч, жорлонд орж, дараа нь нүүр гараа угааж, сахлаа хусаад, эргэж ирж ш и н э гутлаа өмсөн, өрөөн дотуураа хэд алхаж, толины өмнө очиж сонжин харснаа, -ээ, бурхны аврал гэж, -үйлчлэгч дуудах товч руу дарж, өглөөнийхөө цайг шаардав. Тэгэхээр гутал нь таалагдаж! Ашгүй, гайгүй өнгөрлөө! Гуталтай харьцуулахад малгай юу ч биш! Хэрвээ малгай нь ч бас таарсан байх юм бол Власик нөхөр Сталиныг явсны дараа хамгаалалтын бүх хүнд зуу зуун грамм архи өгөхийг тушаана.

Арван цагт Ежов ирэв. Сталин өглөөнийхөө ундыг ууж гүйцээгүй байсан тул Ежовт хамт цайлахыг санал болгов.

Ежов талархан суув.

Сталин түүнд цай аягалах зуур, ширээн дээр байсан цаасыг жаахан цаашлуулахдаа тэр цаас руу Ежовын харц тусахыг анзаарав. Тэдгээрийн дотор түүний “бүтээл” бас байгаа билээ.

Ежов Кировыг алуулсны дараа 1935 оны эхээр “Жигүүрээс илт эсэргүү ажиллагаа руу” гэдэг ном бичихээр сэдсэн ухаантай. Тэгэхэд хүн болгон ном бичих өвчин туссан юм. Буруутан нь Горький. мань хүн, утга зохиолд ажилчин хүмүүс, “хашир” хүмүүс орж ирэх ёстой гэж тунхагласан, ердийн хөл нүцгэн хөвүүн зохиолч болж чадахыг өөрийнхөө жишээгээр үзүүлсэн. Тэгээд Ежов зохиолч болно гэж харайлгасан төдийгүй бичигчээн болсон юмаа түүнд шургуулж, үзэж заалт өгөхийг хүссэн. Авахаас аргагүй болсон.

-Таны гар эхийг би уншаад эхэлчихсэн. Уншиж гүйцэж байгаад ярилцамз. Илтгэлийнхээ сэдвийг авчрав уу.

-Авчирсан.

Ежов цүнхээ нээж, ТХ-ны ирэх Бүгд хурал дээр Бухарин, Рыков нарын тухай тавих илтгэлийн сэдвээ гаргаж ирэв.

Сталин сэдвийг уншиж үзэв. Бухарин, Рыков хоёрыг баахан муулж, элдэв явдлыг тулган тохжээ... Улайм цайм, тас түс тохсон байна, Ежовын хувьд болох зүйл... За яахав! Микоян хавсралт илтгэл тавьж, улс төрийн хэсгийг нь нэмж тодотгоход болно.

Сталин сэдвийг нь буцааж өгөнгөө,

-За, ийм байж, хэн эсэргүүцнэ гэж бодож байна гэж асуув.

-Зөвхөн нөхөр Оржоникизе. Арван хоёрдугаар сарын Бүгд хурал дээр л намайг няцаах гэж оролдоод байсан. Одоо тэгээд үйлдвэр, заводаар баахан хүн явуулж, баривчлагдагсадын талаар материал цуглуулж байгаа.

Сталин цайгаа халбагаар хутгаж, аяганы ёроолд ёотонгийн сүүлч хайлж дуусч буйг харзнав.

“Материал цуглуулж байх нь...” Нохойн гөлөг! Улс төрч ерөөсөө биш, түргэн зантай, богино жолоотой, хийх алхмаа эрэгцүүлж боддоггүй энэ тэрийг нь Ленин мэдчихээд насныхаа сүүл рүү түүнийг өөрөөсөө холдуулсан. Тэгэхэд мань хүн түүнийг дэмжиж, Өвөр Кавказад удирдах ажил дээр байлгаж байгаад, хожим Москвад авчирч, Улс төрийн Товчоонд оруулж, Төв Хянан Шалгах Комиссын даргаар томилсон. Серго өөрийнх нь үгэнд сайн орж, сөрөг хүчинтэй идэвхтэй тэмцэж байснаа гучин оноос өөрийнхөө жинхэнэ араншинг харуулах болж, Кировтой нийлэн эсэргүүцэл үзүүлж эхэлсэн. Чухамхүү Кировыг алуулснаас хойш өөрөөс нь бүрмөсөн хөндийрсөн, ямар нэг юмны үнэр авсан, ямар нэг юм мэдсэн байх, гэхдээ тэр тухай чимээгүй яваа. Ленинград явах гэхээр нь мань хүн явуулаагүй:

-Юу гэсэн үг вэ?! Зүрх чинь ямар сан билээ?! Нам х о ё р удирдагчаа оршуулаг гээ юү?! Бид хориглож байна. Улс төрийн Товчоо хориглож байна. Явдаг юм бол намаас хөөнө шүү, урьдчилан санууллаа шүү!

Захирагдаад яваагүй. Гэхдээ номхроогүй. Зиновьев-Каменевыг

шүүх хурлыг дэмжээгүй, Бухарин, Рыков хоёрыг баривчилсныг эсэргүүцэж байгаа. Хэдхэн хоногийн өмнө Кремлийн хашаан дотор Бухарины авгайг зориуд зогсоож байгаад ярилцсан гэсэн... Бухарин тэр хоёр хэзээний найзууд. Бухарин хүнд аж үйлдвэрийн комиссариатад, түүний хажууд дөрвөн жил шинжлэх ухаан, техникийн асуудал хариуцсан, өдөр болгон уулзахдаа тэр хоёр юу ярьж байсан байхав?

Троцкийчууд, бухаринчуудын аж үйлдвэрийн салбарт явуулсан хорлон сүйтгэх ажиллагааны тухай Оржоникизе ТХ-ны Бүгд хурал дээр илтгэл тавих ёстой. Ямар илтгэл хийх бол? Үйлдвэр, заводаар өөрийнхөө хүмүүсийг явуулж. Яах гэж явуулав? Хорлон сүйтгэх явуулгын талаар материал цуглуулах гээ юү? Тийм материалын хойноос хүн явуулах шаардлага байхгүй, Ежов тийм материал, ёстой, хэдийг л бол хэдийг түүнд өгч чадна. Үүний тулд ДЯАК-т зориуд байгуулсан эдийн засгийн газар бий. Эрхэм Серго түүний материалыг ашиглах дургүй байх нь. Зам харилцааны ардын комиссар Каганович ДЯАК-тай, тэндэхийн тээврийн хэлтэстэй холбоотой ажиллаж болоод байна, гэтэл нөхөр Оржоникизе тийм холбоотой ажиллахыг хүсэхгүй байна. Яг эсрэгээр нь хийж, ДЯАК-ыг илт үл тоомсорлож байна. Хоёр сарын өмнө, арван хоёрдугаар сарын Бүгд хурал дээр Ежовын илтгэлийг үе үе таслаж, бүгд чимээгүй, Бүгд хурал тэр чигээрээ чимээгүй байхад, мань хүн л элдэв асуулт тавьж Ежовыг будлиулан, түүнд итгэхгүй буйгаа харуулаад байсан. Одоо бас итгэхгүй, хорлон сүйтгэгчдийг суллахыг шаардсан, нүүрэлдүүлэхийг шаардаад байхаар нь Пятаковтой нүүрэлдүүлсэн, тэгээд амаараа шороо үмхсэн хэрнээ итгэхийг хүсэхгүй байгаа. Ингэхэд, ер нь “итгэнэ”, “итгэхгүй” гэдэг чинь юу гэсэн үг вэ? Тийм ойлголт намын гишүүн хүнд байхгүй, байх ч ёсгүй. Намын гишүүний хувьд ганцхан “намын удирдамжийг би биелүүлж байна, эсвэл биелүүлэхгүй байна. Намын дайсантай би тэмцэж байна, эсвэл үгүй” гэсэн ойлголт бий. Нөхөр Оржоникизе үүнийг сайн мэдэж байгаа.

Нөхөр Оржоникизед бүх нөхцлийг бүрдүүлж өгсөн, нэр хүндтэй бол нэр хүндтэй, олон түмэн мэдэх үү гэвэл мэднэ, тэр ч бүү хэл, “аж үйлдвэрийн ерөнхий командлагч” гэдэг цолтой болсон, гэтэл мань хүн аж үйлдвэрт ямар юмных нь командлагч байхав? Пятаков болон бусад аж ахуй мэдэх нөхөд л түүний орноос ажиллаж ирсэн. Серго коллегийнхоо хурал дээр нэг үйлдвэрийн даргыг шахаж, юу ч билээ шаардсан гэлцдэг. Цаадах нь,

-Григорий Константинович аа, “хамгийн сайхан хүүхэн ч өөрийнхөө өгч чадах юмнаас илүү юу ч өгч чадахгүй” гэсэн нэг франц зүйр үг байдаг юм гэж хариулжээ.

Серго тэгэхэд,

-Тэгвэл хоёр дахиад өгөхгүй юү! хэмээн ширээ шаасан гэнэ билээ.

Ийм л түвшинд удирдаж байгаа хүн. Малын бага эмч байсан, тэр чигээрээ л үлдэж. Гэтэл түүнийг байдгаар нь өргөмжилж, хот тосгон, гацаа суурин, хамтрал, сангийн аж ахуй, төмөр зам энэ тэрийг түүний нэрэмжит болгосон, ноднин тавин насных нь ойг яаж тансаглаж тэмдэглэлээ дээ. хүнд өөр юу хэрэгтэй юм бэ? Тэгэхэд чинь үгүй шүү, дайсантай тэмцэхийг хүсэхгүй байгаа юм.

Үйлдвэр, заводаар хүмүүс яах гэж явуулав? Хорлон сүйтгэгчдийн тухай материал цуглуулах үүрэг тэдэнд өгөөгүй, харин хорлон сүйтгэгчдийн бурууг үгүйсгэсэн материал цуглуулах л үүрэг өгсөн байж таарна. Сүүлчийн шүүн таслах хурлаар бүрэн илчлэгдсэн Бухарин, Рыков энэ тэрийг өмгөөлж, ирэх Бүгд хурал дээр үг хэлэх гэж байгаа нь тэр. Үг хэлэх гэж байгаа бол хэн нэгэн дэмжинэ гэж найдаж байгаа нь тэр, нүдээ тас аниад үг сүггүй гүвшилцэнэ гэж байхгүй. хэнд найдаж байна вэ? Косиор, Постышев, Эйхе энэ тэрд үү? Тэгвэл Пятаков, Радек хоёр тэднийг алах гэж байсан, тэр тухайгаа шүүх дээр хүлээсэн шүү дээ. мань хүн ийм үгийг өөрийн гараар тэдний мэдүүлэг дээр нэмж бичсэн. Мужийн намын хороодын зарим нэг даргад уу? Юу л бол. Оржоникизе тэдэнтэй зөрчилдөж байгаа, үйлдвэрийн ажил явдалд мужийн намын хороод хөндлөнгөөс хутгалдаж буй мэт гомдоллож байдаг хүн. Ер нь хутгалдаж байгаа нь зөв. түүний гучин дөрвөн онд үүсгэсэн ажил үр шимээ нэгэнт өгч эхэлсэн, намын байгууллагууд аж ахуйн аппаратыг захирдаг болж, техникийн үзэлтнүүдэд үхлийн цохилт өгсөн, гэхдээ тэд нар эсэргүүцлээ үргэлжлүүлж, түүндээ Сергог ашиглаж байна. Тэгэх тусам нь аливаа эсэргүүцлийг язгуураар нь мулт цохих хэрэгтэй, Бухарин, Рыков хоёрыг нэгэн дуугаар зэмлэн буруутгавал зохино.

-Оржоникизегийн хүмүүс, тэгээд, ямар материал олж ирэв? гэж Сталин асуув.

-Хараахан эргэж ирцгээгээгүй байна. Гэхдээ, ажил сайн явж байна, төлөвлөгөө биелэж байна, хорлон сүйтгэх явдал байхгүй, зарим нэг дутагдал, техникийн ердийн эвдрэл бий гэх маягийн юм нотлоно гэж үзэх үндэс байна.

-Папулия Оржоникизегээр юу хэлүүлж амжив?

-Тифлист мөрдлөг явагдаж байгаа.

Энэ хэргийг Өвөр Кавказын хязгаарын намын хорооны дарга Берия хянаж байгаа, өөрт нь илтгэдэггүй гэдгийг Ежов Сталинд ойлгуулж байгаа нь энэ.

Папулия бол Сергогийн ах. Өвөр Кавказын төмөр замын орлогч дарга. Намын ахмад гишүүн. Хувьсгалаас өмнө төмөр замын холбоочин, өртөөний жижүүр байсныг Сталин тодхон санадаг билээ. Хөгжилтэй, гэхдээ хөнгөмсөг нөхөр. Өөрийг нь хөөдөж яваагүй, гэхдээ л хөнгөмсөг. Соёлгүй, боловсрол эзэмших дургүй. Серго бас нэг их номтой хүн биш, гэхдээ хаа нэг ном

нээнэ, Папулия бол тэр ч байхгүй. Нийцтэй, шалвалзуур гавшгай хүн, гэхдээ хийхээсээ дүрэмдэх нь их. Толгой хяргам ширүүлж, хэнийг ч бай, улалзтал нь үнэнийг хэлнэ. Хувийн жаргалыг их хичээнэ, ан ав, найр найдамд дуртай, алиа наргианч, найран дээр бол сайхан ловон. түүнээс “Та чинь Оржоникизегийн ах уу” гэж асуувал, “Үгүй шүү, Серго л миний дүү” гэж хариулна. Берияг үзэж чадахгүй. Хязгаарын намын хороон дээр ирчихээд, ажилтнуудынх нь нүүрэн дээр, “Потийн цаад нэг луйварчин чинь өнөөдөр хүлээн авах юм болов уу?” гэж өндөр дуугаар асууна. Берия, мэдээж, гомдчихно. Юунд гомдож байна? “луйварчин” гэдэг үгэнд үү, эсвэл “потийн” гэсэн үгэнд үү? Уул нь мань хүн Поти хотынх биш, холгүй орших нэг жижигхэн тосгоных. За тэр ч яахав. Берия түүнийг баривчлуулсан нь зөв, гарцаагүй баталгаа гаргаж ирсэн байна лээ. Гэтэл Сергод энэ нөлөөлөөгүй, ахыгаа аврах гэж бууж өгөөгүй. Тэр ч байтугай, түүний буруутай гэдэгт итгээгүй, “түүний мэдүүлгийг миний ширээн дээр тавьчих” гэсэн, Папулиятай нүүрэлдүүлэхийг шаардаж, Лаврентий Берияг элдвээр муулж, Ежовыг, аюулаас хамгаалах байгууллагыг хэлэх хэлэхгүй үгээр дайрч байгаа. Хайртай ахынхаа баривчлагдсанаас дүгнэлт хийсэнгүй.

Сталин өглөөнийхөө ундыг ууж гүйцээд аягаа цаашлуулж, үйлчлэгч рүү хонхдов. Ежов суурийг нь хоёр хуруугаараа дэмнэж байгаад аягаа бас хажуу тийш тавив.

Валечка орж ирээд, аяга, тавгаа хураах зуур,

-Идэж болов уу, Иосиф Виссарианович гэж эелдэгхэн асуув.

-Болсон. Баярлалаа.

Валечка сав суулгаа хурааж тосгуур дээр тавиад, бүтээлгийг хуулж ширээ арчиж байх хооронд Сталин өрөөн дотуураа явж, өвөл түгжээтэй буй сэхээвчний шилэн хаалга руу ирж зогсов. Сэхээвчний цас ороод тогтсон чигээрээ нэлмийж байна. Сталин энэ цасыг арилгахыг хориглосон юм. Мөр нь үлдчих учраас хаалга руу хэн ч ирж зүрхлэхгүй.

Сергогийн араншин ахтайгаа олон талаар төстэй.

Хоюулаа омголон, цочир ууртай, Серго, мэдээж, арай худрагатай, ээ тэр Папулия юу... түүнийг баривчлахаас айцгаагаад байсан шүү. Гар буунаас сална гэж байхгүй, мэргэн буучийг ч хэлэх үү. Залилж байж барьсан, сайхан дөнгөсөн байна лээ... Хотын намын дарга дээр дуудаж. Папулия түүний өрөөнд ортол цаадах нь гар бугаа хуу задлаад сонин дээр тавьчихсан, “задалчихсан чинь буцаагаад угсарч чаддаггүй” хэмээн гомдоллоод зогсож байж.

-Аль вэ, би угсарчихья гэж Папулия хэлжээ.

-Үгүй ээ, би өөрөө угсрах гэсэн юм. Харин чи гар бугаа өгөөтөх, би харж байгаад угсарья, учир жанцанг нь ойлгоод авах ч юм бил үү.

Папулия, тэнэг толгой, бугаа өгчихсөн гэж байгаа. Намын дарга

түүнийг нь бас сонин дээр тавьж байгаад өөрийнхийгөө угсрах гэж баахан бүтэлгүй оролдсон гэж байгаа. Тэгээд уцаарлан, “Энэ муутай хичнээн ноцолдох вэ! Хоюул цаг үрээд

яахав? Чинийхийг харж байгаад угсрах үүрэг нэг хүнд өгчихье, тэр хооронд хоюулаа ажлаа ярьж байя” хэмээжээ. Тэрээр угсраатай, задалсан хоёр гар буугаа сонинд боогоод гарч. Тэгэнгүүт ДЯАК-ын гурван булиа залуу өрөө рүү дайрч ороод Папулиягийн гарыг мушгичих нь тэр. Гэхдээ мань хүн амжуулаад тэр гурвын нүүрэнд хөх няц үлдээсэн төдийгүй, намын даргын бэхний хэрэгслийг хага цохьсон гэнэ лээ... Берия түүнийг ингэж овжин барьсан гэж байгаа. Ежовт бол тэр дайны заль байхгүй л дээ. Муу ясны тээрэм! Гэхдээ хэрэгтэй тээрэм.

Мэдээж, Сергогоос зугуухан салж болно. Эхлээд нэг Холбооны томоохон улсад ТХ-ны даргаар явуулчихъя, дараа нь байдлыг харъя.

Гэтэл цаг хугацаа хүлээх биш. Бухарин, Рыков хоёрыг дуусгах цаг болчихоод байна.

Сталин сэхээвчний хаалганаас холдож, өрөөн дотуураа хэд алхалснаа Ежов руу эргэв.

-Техникийн үзэлтнүүд хараат бус байхыг урьдын адил хүсч, намын удирдлагыг эсэргүүцэж байна, намын эсрэг тэмцэлдээ тэд троцкийч тагнуулчидтай нэгдэж байна. Нам, ард түмэн үүнийг мэдэж байгаа, нөхөр Оржоникизе ч бас мэдэж байгаа. Туршлагатай улс төрч. Троцкийч хорлон сүйтгэгчдийг Бүгд хурал дээр хамгаална гэдэг бол найдваргүй, нэгэнт ялагдсан хэрэг рүү хальтрана гэсэн үг гэдгийг ойлгож байгаа. Ер нь Бүгд хурал дээр хэн ч түүнийг дэмжихгүй, аягүй бол яриулахгүй, индэрээс хөөж буулгах байх гэж би санаа зовж байна, тэр байтугай хүнийг хөөж буулгаж байсан удаатай юм чинь. Тэгвэл түүний зүрх яах бол? Бүгд хурал дээр бөглөчихгүй байгаа?! Зүрх муутай хүний сэтгэл их дэвэрвэл тун халгаатай. Нөхөр Зержинский сэтгэл нь дэвэрч байгаад яг Бүгд хурал дээр өөд болсон. Гэхдээ нөхөр Зержинский Каменев, Пятаков мэтийн шаарнуудыг илчлэн үг хэлж байгаад өөд болсон, харин нөхөр Оржоникизе Бухарин, Рыков нарын шаарнуудыг өмгөөлж байтал зүрх нь бөглөчих вий. Үүнийг ард түмэн юу гэж үзэх вэ? Бид түүнийг яаж оршуулах вэ? Намын нэг удирдагчийн байдлаар уу, эсвэл намын нэг дайсны байдлаар уу? Намын хувьд, зөвлөлтийн бүх ард түмний хувьд маш том санамсаргүй явдал болно.

Ежов Сталинаас нүд салгалгүй, хөшсөн мэт зогсчихоод, чих тавин сонсож байна.

Сталин үргэлжлүүлэв.

-Тийм учраас нөхөр Оржоникизе тагнуулчид, хорлон сүйтгэгчдийг өмгөөлсөн үг хэлэх ёсгүй. Гэхдээ Бүгд хурал дээр тэр дуугүй байх ёсгүй. Яагаад ёсгүй байхав? Яагаад гэвэл, нөхөр Оржоникизе яах гэж тагнуулуудаар өөрийгөө хүрээлүүлсэн юм бэ? гэдгийг Бүгд хурал түүнээс асуух эрхтэй. Манай аж үйлдвэрийг яах гэж хорлон сүйтгэгчдийн гарт өгөв? Ийм асуултад нөхөр Оржоникизе хариулах ёстой, хариулах үүрэгтэй. Нөхөр Оржоникизе юу хариулж чадах вэ? Юу ч чадахгүй! Нөхөр Оржоникизегийн өөрийгөө зөвтгөх тайлбарыг Бүгд хурал хүлээж авахгүй. Нөхөр Оржоникизе төвөгтэй, хэцүү, эмгэнэлт байдалд оржээ. Атаархах юм биш! Тэгэхээр мань хүн хорлон сүйтгэгчдээ хамгаална уу, эс хамгаална уу, өөрийгөө зөвтгөнө үү, яана, Бүгд хурал түүний үгийг заяа нь сонсохгүй. Аль ч тохиолдолд түүний зүрх бөглөчихнө. Бүгд хурал дээр л зүрх нь бөглөчихвөл түүний хувьд хамаагүй дээр. Зүрх бөглөнө гэдэг бол ердийн үзэгдэл, ард түмэн ойлгоно. Нам, ард түмний хайрт хүү чигээрээ халин одох уу, эсвэл нам, ард түмний дайсан болж тонилох уу? гэдэг асуулттай одоо нөхөр Оржоникизе тулгараад байна. Тэр энэ асуудлыг бодож, шийдэж байна. Тэр ийм л юм өнөөдөр

бодож байгаа.

Сталин өрөөн дотуураа дахин холхисноо,

-Нөхөр Оржоникизег дөрвөн гар буутай гэж та надад хэл лүү? гэж санаандгүй юм асуув.

-Тэгсэн.

Сталин толгой сэгсрэв.

-Хувьдаа олон зэвсэгтэй байх чинь муу шүү. Нүдэнд нь эрээлжлээд байж мэднэ. Тэгээд сэтгэл алдарсан үед өөрийгөө буудчихаж ч болох. Тийм явдал бий. Ялангуяа нөхөр Серго шиг омголон хүмүүс. Ялангуяа нөхөр Серго шиг хүнд байдалд орчихсон үед. Томскийг өөрийгөө буудаж амиа хорлоход, “троцкийч-зиновьевч алан хядагчидтай тогтоосон холбоо сүлбээндээ ороолдчихжээ” гэж нам шуудхан хэлснийг Серго сайн мэдэж байгаа. Нам түүний тухай тэгж хэлэхгүй, тэгж бичихгүй, нам түүнийг амиа хорлосон гэж мэдээлж, нөхөр Оржоникизегийн нэрийг бузарлахгүй гэдгийг Тэрээр сайн ойлгож байгаа. Мэдээж, зүрх муу хүн аж төрөх хэцүү, намынхаа үйл хэрэгт санасан чинээнийхээ ач тусыг хүргэх боломжгүй. Энэ мэтээс болж амиа хорлосон явдал бий. Жишээ нь, Карл Марксын охин Лаура, түүний нөхөр Поль Лафарг хоёр. Социализмын үйл хэрэгт ач тус хүргэж чадахгүйгээ мэдмэгц амиа хорлоцгоосон. Тэгтлээ хөгширсөн улс биш шүү дээ. Тэрүүн шиг нөхөр Оржоникизе эмгэг зүрхтэй цаашаа аж төрж чадахгүй.

Сталин Ежовын дэргэд ирж зогсоод,

-Нөхөр Сергод өөр зам байхгүй болов уу гэж зовох юм... хэмээн гунигтай өгүүлэв.

“Бристоль” зочид буудлын тухайд ноцтой алдаа гаргасан учир Дьяковьг ажлаас нь халж, түүний бараа сураг тэгээд тасарчээ. Оронд нь Шарокийг томилов. Шарок түүний тохойвчтой эвлэгхэн суудалд сэтгэл хангалуун очжээ. Албан тушаал ч ахиж, авдаг цалин ч нэмэгдэж.

Тэрээр олон үүрэгтэйн дотор тэдний тасгаар хэрэг нь мөрдөгдөх хүмүүсийг баривчлах үүрэг бий. Гучин зургаан оны эцсээр тэдний барих хүний тоонд Иван Григорьевич Будягин таарчээ.

Молчанов түүнд,

-Будягиныг өөрөө барь, боловсон харьцаарай гэж тушаав.

Эхний мөчид Шарок балмагдан сандарч, түүнийг таньдаг, охинтой нь нэг ангид есөн жил хамт сурсан учраас Будягиныг баривчилж чадахгүй гээд золтой л хэлчихсэнгүй. Ийм нөхцөлд,

-Намын дайснуудыг бид таних ёсгүй. Ер нь ч хар ажлаас цэрвэхийн хэрэггүй. Зержинский тийм ажлаас жигшихгүй, өөрөө баривчилгаанд явдаг байсан гэх ганцхан улигт хариу байдгийг сайн мэдэх учраас тэсч өнгөрчээ.

Тэгээд хариу дуугаралгүй, тушаалыг ёсоор болгохоор хүлээн авч, энэ шөнийн ажлын хэсгүүдийг бүрдүүлж, шаардлагатай баримт бичгийг бэлтгэсэн боловч Будягин руу ахлах төлөөлөгч Нефедовыг явуулж, өөрөө дивиз командлагчийн албатай нэгэн цэргийн даргыг баривчлахаар шийдэв. Даргынхаа шууд шийдвэрийг зөрчсөн хэрэг. Нэг бишдвэл их тусгүй юм болно. Гэвч Будягин руу очиж даанч зүрхэлсэнгүй.

Шарок Будягинаас өөрөөс нь ичих зовох юм байсангүй. Яая гэхэв, албан үүрэг тийм юм чинь. Бас Ленатай уулзахаас ч тэгтлээ зовсонгүй. Хэрвээ тэр хоёр хэсэгхэн төдийд хоюулхнаа таарлаа гэхэд мань хүн түүнд, “Лена, надад энэ бол маш муухай байна, гэхдээ тушаал бол тушаал шүү дээ, чи ойлгох ёстой” гэж хэлэх байсан. Бүхэлдээ бол даван туулж болох зүйл.

Зовлонгийн учир өөр юманд байгаа юм. Тэнд, тэр Зөвлөлүүдийн 5 дугаар байшинд, Будягины гэрт түүний хүү байгаа. Хүү нь! Шарок түүнийг хэзээ ч үзээгүй, үзэхийг хүсээ ч үгүй. Гэхдээ тэр хөвүүн амьд мэнд аж төрж байгаа. Даруй нэг сар Будягины байрыг гаднаас нь ажиглаж байгаа бөгөөд Тэрээр төлөөлөгч нартаа, Будягины зээ хэзээ салхинд гардаг, хэн гаргадаг, хэн тэдэн дээр очдог, тэд хэнтэй ярилцдагийг тодорхой илтгэж байхыг тушаасан аж. Мөрдлөгт, мэдээж, ийм мэдээлэл хэрэггүй, гагцхүү өөрт нь л хэрэгтэй. Тэрээр хөвүүн амьд эсэхийг л мэдэх гэсэн юм. Бурхны авралаар үхсэн бол хаа хаанаа амар байхгүй юу. Шарокт энэ хөвүүн тэртэй тэргүй хэрэг байхгүй, Ленаг эрт, орой алин боловч шоронд хийнэ, эсвэл их л сайндаа Сибирьт юм уу, Казахстан руу цөлөгдөнө, тэгж гэмээ нь нялх хүүхэдтэй хүн чинь улам их зүдрэнэ. Хэрвээ хөвүүнийг хүүхэд асрах газар руу явуулчихвал тэнд овог, нэрийг нь солиод, эх нь тэртэй тэргүй түүнийгээ алдана гэсэн үг. Ер нь хүүхдийн хувьд ч гэсэн цөллөг, хүүхэд асрах газраар тарчилж явснаас үхсэн нь дээр.

Гэтэл хүү нь үхээгүй төдийгүй, хамрын ханиад ч хүрдэггүй бололтой. Төлөөлөгчдийн мэдээлснээр бол түүнийг асрагч авгай өдөрт хоёр удаа салхинд гаргадаг, амралтын өдөр бол

ээж нь, өөрөөр хэлбэл, Будягины охин салхилуулдаг аж. Тэгэхээр тэр хөвүүн тэнд, тэр байранд байж байгаа, Иван Григорьевичийг баривчлах, тэднийд нэгжлэг хийх үед тэнд байж байна гэсэн үг.

Ийм нөхцөлд Ленагийн толгойд юу орж ирж, ямар араншин гаргахыг урьдчилан хэлэх аргагүй. Хүүхдээ гаргаж ирээд, өвөр рүү нь шидэж,

-Тэгвэл өөрийнхөө хүүг ч барь! Шоронд хий! гэж ч мэднэ.

Бөөн дуу шуугиан, хүүхдийн уйлаан майлаан болно.

Шарок зөндөөн олон баривчлагаанд оролцож, олон нэгжлэг хийсэн болохор орилоон, чарлаан, хүүхдийн уйлаанд нэгэнт дасчихаад байгаа л даа. Гэхдээ Будягиныд очиж т и й м хэрүүл дэгдвэл албан ёсны төрийн үйл ажиллагааг айл гэрийн явган хэрүүл болгочихно, тэгээд Шарок ардын дайсны гэр бүлийнхэнтэй ураг төрлийн холбоотой нь илэрч, тэр тухай сураг чимээ маргааш нь гэхэд комиссариатаар нэг тарчихна. Тийм учраас Будягиныд өөрөө очиж хэрхэвч болохгүй.

Юу л болвол болог. Молчановын өмнө дараа нь яаж ийгээд өөрийгөө зөвтгөчихнө. Өөрөө дивиз командлагчийг авна, Будягин руу ахлах төлөөлөгч Нефедовыг явуулна.

Шарок орой нь Нефедовыг дуудаж, заавар өгөөд, нэгжлэгийг маш нарийн хийх хэрэгтэй, Будягиныд хайх юм гарцаагүй бий гэж хэлэв. Будягин хуучин ТХ-ны гишүүн байхдаа хадгалж байх эрхтэй байсан намын нууц бичиг баримтууд байж магад, ТХ-ноос хусагдсанаас хойш түүнийгээ өгөх ёстой газарт нь хураалгах ёстой, гэтэл хураалгаж уу, үгүй юу? Түүнчлэн элчин сайд байх үеийнх нь үйл ажиллагаатай холбогдсон бичиг баримт мөрдлөгийн ажилд хэрэг болох талтай. Бас Будягинд гар буу байж магад, тэгвэл буутай байх эрхийнх нь хугацаа гарцаагүй хэтэрчихсэн байгаа даа. Хэрэв тэгсэн бол иргэн Будягин гэртээ зэвсэг хадгалах эрхгүй атлаа хадгалж байна гэсэн үг. Ямар зорилгоор тэр вэ?

-Зөвшөөрлийн тухай мартав гэж Шарок төгсгөлд нь давтан хэлэв.

Нефедов юуг ч мартсангүй. Шарокт даалгасан ажилбарууд элдвээр бааралгүй бүтэв. Будягин, дивиз командлагч хоёрыг өглөө гэхэд комиссариатын дотоод шоронд авчирсан байлаа. Шарок нойргүй хоносон учир нүдний хор гаргахаар хариад, үдээс хойш эргэж ирэв. Өрөөндөө орж нэг хавгаст хэрэг дэлгээд, Молчанов руу дуудахыг түгшүүрлэн хүлээлээ. Тэрээр,

-Дивиз командлагч зэвсэг хэрэглэж магадгүй гэсэн сэжиг төрсөн. Тийм учраас хүмүүсээ явуулж зүрхлээгүй, өөрөө хамт явахаар шийдсэн гэж тайлбар тавихаар шийджээ.

Молчанов түүний өрөөнд өөрөө хүрээд ирэв. Гэхдээ ганцаараа биш. Агранов тэр хоёр ардын комиссар Ежовыг дагалдан иржээ.

Шарок ухасхийн босч ёслоод,

-Тасгийн даргын туслах Шарок. Нөхөр ардын комиссар сайн байна уу хэмээн илтгэв.

Давжаа биетэй Ежов түүнийг цоргих мэт ширтэв.

-Юу хийж байна?

Шарок мөрдөж байгаа хэргээ илтгэв.

Ежов цоргисон харцаар ширтсэн хэвээр.

-Тамхи хүрэлцэж байна уу?

-Тийм ээ, нөхөр ардын комиссар, хүрэлцэж байна. Таныг тэр удаа тамхи ирүүлсэнд талархал илэрхийлье.

-Мартаагүй байх нь хэмээн Ежов хайнга өгүүлэв.

Тэгээд гарлаа.

Араас нь Агранов, Молчанов хоёр ч гарав.

Маргааш нь Шарокийг Ежов руу дууджээ.

Одоо Ежовын өрөө байшингийн зүүн жигүүрт байдаг болжээ. Шатаар өгсөж уруудан байж тийшээ очно. Шатны тавцан болгон дээр бичиг баримт шалгана.

Шарок тэр төвөгтэй замаар бичиг баримтаа шалгуулан явах зуур ардын комиссар түүнийг дуудах болсны учир шалтгааныг эрэгцүүлэн бодов.

Лав л өчигдөрийнх нь түүнд товч илтгэсэн хэргээс болж дуудаагүй. Тэр бол удахгүй болох шүүн таслах ажиллагаанд холбогдолгүй жижигхэн хэрэг, Ежовын сонирхлыг өчүүхэн ч татах ёсгүй. Бас Шарок Будягиныг баривчлахад биечлэн оролцоогүйгээс болоогүй. Молчанов юу гэж энэ тухай Ежовт илтгэхэв дээ. Захиргаандаа буй хүмүүсийн талаар гомдол мэдүүлж байгаа бол чи л өөрөө муу дарга. Өөрөө тэдэнтэйгээ учраа ол гэх шүү дээ. Тэгэхээр өөр л юм байх нь. Ежов тамхи явуулснаа мартаагүй байгаа юм чинь нөгөө төвөгтэй нөхцөлд Шарок ямар зан гаргасныг мартаагүй байлгүй. Тэгэхэд мань хүн Ягода болон шууд дарга нарынх нь хэрэгсээгүй саналыг Ежовт зүрхлэн хэлсэн. Энэ Ежовт таалагдсан байж таарна. Өөр нэг зүйл. Мөрдөгдөж буй хүнд хуурамч ялын бичиг үзүүлснээ Шарок шууд хүлээсэн. Ийм хууль бус явдлыг Ежов өөлж болох. Гэтэл өөлөөгүй. Сайшааж, халамжлан тамхи ирүүлсэн. Тамхины мухлагт хайрцаг “Герцогивина флор” бол ердөө л нэг хайрцаг тамхи. Харин ТХ-ны нарийн бичгийн даргаас жирийн нэгэн мөрдөгчид ирүүлсэн хайрцаг тамхи бол хамаагүй илүү дорвилог зүйл, энэ бол шагнал. Тийм ч учраас Шарок Ежовын дуудсаныг муугаар бодсонгүй. Ягодаг халагдсанаас хойш энд гарч буй өөрчлөлтүүдтэй л холбоотой болов уу. Нэг удирдагч нөгөөгөөр солигдоход боловсон хүчний холио сэлгээ зайлшгүй.

Ежов уртаашаа гурван метр орчим болов уу гэхээр том ширээний ард сууж байв. Өрөө нь ч тиймэрхүү ширээ дүйхээр цэлгэр аж. Ханаар нэг шилэн нүүртэй номын шүүгээнүүд, цонхны шал шүргэм хөшигнүүд, үнэтэй нүсэр тавилга. Ежовын сандлын ар хананд Сталины хөрөг өлгөөтэй байна. Хөргөн дээр Сталин бас бичгийн ширээний ард суучихсан юм бичиж байна.

Ежов Шарокийн мэндийн хариуд толгой дохиод, түүнийг гөлөрсөн хачин нүдээр харж,

-Суу гэж хэлээд ширээ рүү нь тулгаж тавьсан бас нэг ширээний цаадах сандал руу заав.

Шарок суулаа.

-Би таны хувийн хэрэгтэй танилцсан, гадаад хэлний мэдлэгийн тухай асуултад та ингэж хариулжээ... хэмээн Ежов биеийн байцаал руу харав. -Та франц, германаар уншина, толь ашиглан орчуулна гэж бичсэн байна. Тодруулбал юу гэсэн үг вэ?

-Манай сургуульд франц хэл заадаг байсан, би сургуулийн хөтөлбөрийн хэмжээнд үзсэн. Харин дээд сургуульд герман хэл үзсэн гэж Шарок тайлбарлав.

-Та алийг нь илүү мэдэх вэ?

-Францад гайгүй байсан, гэхдээ нэлээд мартсан. Цаг хугацаа ч их өнгөрлөө, дадлага ч байсангүй. Дээд сургуульд герман хэлийг ёс төдий заадаг байсан, миний мэдлэг ч тун хомс доо.

-Та франц хүнтэй ойлголцож чадах уу?

-Ээ, чадахгүй байх гэж Шарок үнэнээ хэлэв. -Ойлгохын тухайд бол магадгүй, гэхдээ л эргэлзэж байна, францчууд их түргэн ярьдаг юм билээ.

-Та хэл үзэх хэрэгтэй болно. Одоо манай байгууллага шинэ хүчээр сэлбэгдэж байна. Нам, комсомолын гишүүн залуучууд, үндсэндээ ажилчин залуучууд орж ирж байна. Бид тэднээс гадаад хэлний мэдлэгтэй байхыг шаардах боломжгүй. Харин та бол дээд боловсролтой хүн, наад зах нь нэг гадаад хэл мэдэж байх үүрэгтэй. Та дунд, дээд сургуульд хэл үзэж байсныг хэлэх үү, улс танд хөрөнгө зарж байж шүү дээ. Франц хэлнийхээ мэдлэгийг сэргээхэд танд ямар хугацаа хэрэгтэй вэ?

-Өдөрт хэдэн цаг хичээллэх, ямар багш таарахаас л хамаарна.

-Танд цаг хангалттай байх болно, багш ч сайн хүн байна. Танай гэр бүлд цэргийн хүн бий юү?

-Цэргийн хүн үү? Байхгүй.

-Хамаатан садны чинь дотор?

-Байхгүй. Байгаа ч үгүй. Миний эцэг оёдолчин, өвөө ч бас оёдолчин байсан.

-Танилуудын чинь дотор?

-Байхгүй. Байхгүй шүү.

-Бод доо. Дунд, дээд сургуулийн чинь нөхдийн эцэг эхийн дотор?

Шарок дал мөрөө хавчив.

-Байхгүй ээ. Байхгүй. Дээд сургуулийн манай ангийнхний эцэг эхийг би мэдэхгүй, тэд нар голдуу өөр хотынх учраас дотуур байранд суудаг, би Москвагийнх болохоор гэртээ суудаг байсан. Дунд сургуульд зарим нэг хариуцлагатай ажилтны хүүхдүүд цуг сурдаг байсан, гэхдээ тэдний эцэг эхчүүдийн дотор цэргийн хүн байгаагүй, ер нь ч би ангийнхантайгаа аль хэзээний уулзалдахаа больсон... Харин манай ангийн Максим Костин гэдэг залуу цэргийн дунд сургуульд орсон, төгсөөд нэг тийшээ явсан. Чухам хааш нь томилсныг би мэдэхгүй. Тэр үеэс хойш их уджээ, би дунд сургууль төгсөөд арван жил болж байна. Тэр Максимын ээж манай хөгшчүүлийн суудаг байшинд хашаачин хийдэг байсан. Бодвол одоо ч ажиллаж байгаа байх.

-За, тийм байж. Та гадаад хэлтэст шилжиж байна. Өнөөдөр ажлаа хүлээлгэж өгөөд, гадаад хэлтсийн дарга нөхөр Слуцкий дээр оч. Одоохондоо нөхөр Шпигельгласын удирдлагад ажиллах болно гэж Ежов хэлэв.

Ежовын харц хөдөлгөөнгүй хүйтэн хэвээр байвч, “одоохондоо” гэж хэлэхдээ хөхөлбөр нүд нь гялсхийх шиг болсноо тэр даруй унтрав.

-Ажлынхаа хажуугаар хэл үзнэ. Хичээлд чинь зориулж цаг гаргаж өгнө. Өдөр бүр. Нөхөр Шпигельглас танд тайлбарлаж өгнө.

Ежов босч цэрэг цамцаа засав. Үнэхээр намхан хүн юм аа.

-Таны цол, цалин хэвээрээ үлдэнэ.

Тэгээд нүд нь дахин гялсхийж,

-Одоохондоо... гэж нэмж хэлэв. -Тэгээд байдлыг харъя. Таны хувьд энэ бол шинэ ажил. Тэр яахав, та гартаа оруулаад авна. Ахмад ажилтнууд яаж ажиллаж байгааг хар. Сайн ажигла...

Сүүлчийн хоёр үгийг дууныхаа өнгөөр зориуд ялгаж хэлэх ч шиг, үгүй, Шарокт тэгж санагдсан ч байж магадгүй.

За яамай, юм юм сайхан боллоо. Хэлний хичээл наад зах нь хагас жил, аягүй бол, бүтэн жил ч болж мэднэ, тэгэхээр энэ хугацаанд мань хүн дээр нэг их ажил овоолоод байхгүй нь лав. Гадаад хэлтэст, өөрөөр хэлбэл, тагнуулын хэлтэст шилжсэнээр мань Шарок ёстой шар махтай хатаадаг мөрдөнгийн ажлаас чөлөөлөгдөнө, нөгөө шөнө дамнасан байцаалт, зодоон нүдээн, цус нөж, орилоон чарлаанаас сална, үүний хамтад Будягины хэргээс хөндийрнө, түүний хэргийг мөрдөх сонирхол Шарокт даанч байхгүй билээ. Гадаад хэлтсийн ажилтнуудыг шаардлагатай үед яаралтай мөрдлөгийн ажилд татаж оруулах нь бий, гэхдээ тун ховор, нөгөөтэйгүүр мань хүн хэлний хичээлтэй байх учраас түүнийг энэ бүхнээс чөлөөлж таарна биз.

Хилийн чанадад ажиллах нь гарцаагүй аюултай, гэхдээ гадаад хэлтэст түүнийг тагнуулчийн ажилд сургахгүй шүү дээ. Гаднын гаралтай, гадаадад олон жил амьдарсан, унаган хэлтэй,

орон нутгийн нөхцөл байдал, зан заншлыг мэдэх элдэв еврей, польш, латви, герман төдийгүй оросууд ч мундсан биш. мань хүн бол нэг орон юм уу, бүс нутгийг хариуцаж, мэдээллийг эмхлэх, тагнуулын мэдээг боловсруулах ажил хийх байх. Нэр төртэй, тайван ажил. Гадаад хэлтсийн бүх ажилтан дээд боловсролтой, хилийн чанадад сууж асан хүмүүс, гадаадын коммунист намын гишүүн, улс төрийн цагаач явсан хүмүүс олон бий, товчдоо намын сэхээтнүүд.

Шарок Ежовоос буцаж ирээд, ардын комиссарын өөртэй нь ярьсан зүйлийн тухай Вутковскийд илтгэв.

Вутковский тэр тухай хэдийн мэдэж байсан учир ажлаа ахлах төлөөлөгч Нефедовт хүлээлгэж өгөхийг Шарокт тушаав.

-Танд амжилт ерөөе. Манай тасагт хийж байсан ажлын чинь талаар би сэтгэл дүүрэн байсан учраас ардын комиссарт таны тухай эерэг тодорхойлолт гаргаж өгсөн юм хэмээн Вутковский чин сэтгэлээсээ өөриймсөг ярив. -Танаас салахад надад харамсалтай л байна. Энэ гурван жилд бид бие биендээ даслаа, юу эсийг үзсэн гэхэв... Гэвч яах ч арга алга. Бид намдаа зүтгэж яваа улс. Ер нь ч түүх бидний амьдралыг тэгж үнэлэх байх, бидний амьдрал бидний мэдэлд биш, намын мэдэлд байсан гэдгээр л үнэлэнэ гэж бодож байна.

Шарок юун тухай ярьж буйг нь ойлгож байгаа учир дотроо түүнийг өрөвдөх шиг болов. мань Шарок жинхэнэ тагнуулчийг барих ц э в э р х э н ажилд шилжиж, Вутковский өөрөө тагнуулчийг зохиомлоор бодож олдог балиар ажил дээрээ үлдэж байна. Тэгээд намын нэрээр хайцаалж байна... Өөр ч яах вэ дээ? Өөр юугаар хаацайлах сан билээ?

-Таны аз дайрчээ. Сергей Михайлович Шпигельгластай ажиллах юм байна. Ёстой гарамгай тагнуулч, түүнээс мөн ч их юм сурч болно доо.

Шпигельглас гарамгай тагнуулч гэдгийг Шарок ч бас дуулсан, комиссариатад алдар нь тэгж түгсэн, нэр нь нууц далдын үүлэнд умбасан хүн. түүнийг үзсэн хүн ховор, Шарок бол ерөөсөө хараагүй аж. Гадаад хэлтэс хамгийн дээд давхарт байрладаг, Шпигельгласыг доод давхруудаар бууж үзээгүй хүн гэлцэх. түүний дүрээ хувилгах чадварын тухай өдий төдий домог бий. Европын нэг улсын нийслэлд Шпигельглас нууцаар амьдарч байхдаа хавчны наймаа эрхлэх болжээ. Тэгээд наймааны од нь мандаж, бараг бүх хотоороо гагцхүү түүнээс хавч худалдаж авдаг болсон тул тэр ажлаа арга буюу орхиж явахад хүрсэн гэдэг, олонд зартай байх чинь өөрт нь аюултай шүү дээ.

Шпигельглас Москвагийн их сургууль төгссөн, тэр үеийн захирал Вышинскийн ивээл дор байсан гэх. Тэрээр хэд хэдэн хэлийг төгс мэднэ, өндөр боловсролтой, өргөн мэдлэгтэй тагнуулч, гадаад хэлтсийн өмнөө барьдаг мэргэжилтэн, ахмад ажилтан. Овжин, зальтай, хүний ая олохдоо эвлэг хэлтсийн дарга Слуцкий комиссариатын удирдлага, Төв Хороо энэ тэрийн дээгүүр газраар жаалж явдаг бол Шпигельглас дээр бүх учиг нийлж, тагнуулын бүх сүлжээ түүний гарт байдаг гэх.

Цуг ажиллах хүнийхээ тухай Шарокийн мэдэх юм ердөө л энэ. Шарок сэхээтнүүдэд ер нь дургүй, гэхдээ барлагтай ажилласнаас сэхээтэн хүнтэй ажилласан нь дээр гэдгийг

Вутковскийтэй хамтран ажилласан туршлагаасаа ухаарч авчээ.

Слуцкий Шарокийг баяртай угтав. Худлаа л даа. Гарал үүслээрээ ч, ажил төрлөөрөө ч хилийн чанадад ямар ч холбогдолгүй, хэл мэдэхгүй хүнийг Ежов өөрөө ирүүлснийг гайхшран болгоомжилж байгаа. Үүний цаана юу байна вэ?

Шпигельглас ч бас болгоомжилж байгаа нь мэдээж, гэхдээ дуу цөөтэй, хянуур, төлөв тэrvээр тийм царай огт харуулсангүй, эвлэгхэн харьцав.

-Таныг хэлний мэдлэгээ жаахан сэргээх хүсэлтэй байгааг нөхөр Ежов урьдчилан мэдэгдсэн.

-“Жаахан сэргээх” гэдэг чинь дэндүү зөөлхөн үг байна хэмээн Шарок инээмсэглэв. -Би дунд сургуульд л үзэж байсан, одоо хуу мартчихсан, арван жил өнгөрчихлөө.

-Та аль сургуульд сурч байсан юм бэ?

-Кривоарбатын хөндлөн гудамны 7 дугаар сургууль, хуучин Хвостовын гимнази.

-Франц хэл хэн зааж байв?

Шарок тийм асуулт тавьсанд гайхсан боловч, багшийнхаа нэрийг мартчихаагүй, одоо хэр санаж байсан учраас нэрлэлээ.

-Өө, Ирина Юльевна, ёстой сайн багш. түүний сурагчиддаа суулгаж өгсөн мэдлэг мартагдсан ч гэсэн бүрмөсөн арилна гэж байхгүй хэмээн Шпигельглас тосгон авч, -түүнээс гадна хүүхэд ахуйдаа үзэж байсан хэл түргэн сэргэдэг юм гэв.

Нэн гайхалтай хэрэг. Дунд сургуулийн жирийн нэгэн багш Ирина Юльевнаг яаж мэддэг байна?

Шарок тэсэлгүй,

-Та хоёр танил юм уу? гэж асуув.

-Би түүнийг мэднэ гэж Шпигельглас зувчуулсхийв.

Шпигельглас энэ уулзалтад зориуд тухайлан бэлтгэж, тэгснээ шууд ойлгуулах гээд байна гэж үү? Гэтэл Шарокийг чухамдаа ганцхан хоногийн дотор багтааж нааш нь шилжүүлсэн шүү дээ. Хэдий завандаа амждаг байна?

-Хэлний бүлэг өдөр бүр өглөөгүүр хичээллэнэ. түүнээс гадна та тусгай бэлтгэл хийх ёстой. Та ямар зэвсэг эзэмшиж чадах вэ?

-Гар буугаар буудна.

-За яахав, зааварлагч учрыг нь олно. Таны ажлын өдөр найман цагт дуусна, гэрийн даалгаварт хоёр гурван цаг үлдэнэ гэсэн үг. Ажлын хувьд гэвэл, та цагаач цагаантнууд,

түүний дотор ОНЦХ-Оросын Нийт Цэргийн Холбооны асуудлыг хариуцсан хэсэгт орж ажиллана. Энэ бол хуучин цагаан армийн офицеруудын холбоо. Төв нь Парист байдаг, генерал Миллер тэргүүлдэг юм. Танд холбогдох материал, ном зохиолыг өгнө, аль болохоор түргэн гартаа оруулж авахыг хичээгээрэй.

Сургууль дээр дүлэгнэсэн байдал долоо хоног үргэлжлэв. Дараа нь бүх намын гишүүнийг районы намын хянан шалгах комисс дээр дуудлаа. Сургуульд намын гишүүн тав: Алевтина Федоровна, Нина Иванова, нийгэм судлалын багш Василий Петрович Юферов, аж ахуйн дарга Яков Иванович, одоо хэр орлогч гишүүн байгаа лаборант Костя Шалаев.

Намын хянан шалгах комисс Глазовын хөндлөн гудамны өнцөг дээр районы намын хорооны байшинд байрлана. Жижгэвтэр өрөөнд ширээний ард намын комиссын гишүүд сууцгааж байна. Шалгалтын хэсгийнхэн мөн тэдэнтэй зэрэгцэн сууцгаажээ. Цонхны тэндэх буланд хүрэн костюмтай, шар цамцтай, шар зангиатай царайлаг залуу хөлөө ачаад сууж байна.

Шалгалтын комиссын дарга дүнгээ илтгэж, Алевтина Федоровнад тулгасан зэмлэлийг комисс бүрэн дэмжиж байгааг нотлов. Ийм дүгнэлтийн үндсэн дээр Алевтина Федоровнаг сургуулийн захирлаас халж, намаас хөөх асуудлыг авч үзэх, сургууль дээрх улс төрийн ажлаас өөрсдийгөө хөндийрүүлж, сонор сэрэмж алдсан бусад гишүүнд сахилгын арга хэмжээ авах санал оруулав.

Эдгээр үгс тархи руу татаад авах мэт сонсогдоо. Намаас хөөнө гэдэг бол өнөөгийн нөхцөлд баривчлахтай утга нэг. Нина цүнхнээсээ алчуураа гаргаж хөлс чийхарсан духаа арчаад Алевтина Федоровна руу нэгэнтээ харав.

Алевтина Федоровна эршүүд царайтай байна. Комиссын илтгэлд дурдсан баримтууд зөв боловч хийсэн дүгнэлт нь буруу. Алевтина Федоровна комиссынхонд Нинагийн хэлсэнтэй ерөнхийдөө төстэй боловч нам, засгийн холбогдох тогтоол шийдвэрээс иш татан, илүү үнэмшилтэй, илүү жинтэй үндэслэлүүд гаргаж тайлбарлав. Тэрээр Туся Наседкинаг хэрүүлийн эзэн, хов живийн донтон, бүдүүлэг харанхуй хэмээн хатуухан үгээр зэмлэн буруушаалаа.

Дараа нь Василий Петрович Юферовын ээлж ирж үг хэлэв. мань хүн мэдээлэл бичсэн комсомолын гишүүдэд зохих ёсоор анхаарал тавьсангүй гэж сургуулийн захиргааг шүүмжлэв. Өнөөгийн улс төрийн хурц байдалд залуу хүмүүс өөрсдийнхөө зорилтыг т э г ж л ойлгож байна, тийм учраас тэдний үгийг сонсож ярилцаад зөрчилд хүргэлгүй хэл амаа ололцож, тэдний улс төрийн идэвхийг зөв гольдролд оруулах хэрэгтэй байсан байна. Сургуулийн захиргаа зөвхөн сурлага дээр анхаарлаа төвлөрүүлж байжээ гэсэн сэтгэгдэл төрж байна. Энэ бол сайн хэрэг, гэхдээ зөвлөлтийн сурагч хүний нийгмийн нүүр царайны тухай, боловсролтой бас социализмын төлөө сахилга дэгтэй тэмцэгчдийг өсгөн хүмүүжүүлэх тухай мартах хэрэггүй...

Юферовын нойр хүргэм нэгэн хэмийн дуунд хүмүүс залхах янзтай, хянан шалгах комиссын нэг гишүүн эвшээснээ халхалж сахлаа илэх дүр эсгэв. Үүнийг анзаарсан Юферов түргэвчлэн үгээ дуусгав. Алевтина Федоровнаг үүрэгт ажлаас нь халах ёстой эсэх, намаас хөөх эсэх тухай Тэрээр юу ч дурссангүй. Харин өөрийнхөө тухайд бол энэ сургуульд хавсарч ажилладаг, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үндсэн ажилтан гэдгийг харгалзан үзэхийг хүсэлт болгов.

Нина комиссын дүгнэлт, саналыг зөвшөөрөхгүй, Алевтина Федоровнагийн тайлбарыг итгэл үнэмшилтэй гэж үзэж байгаагаар товч бөгөөд эрсхэн хэлэв.

Яков Иванович зам мэдэхгүй жолооч таарсан учраас өөрөө бүхээгт суухаас өөр аргагүй байсан, харин тэвшин дээр байсан хоёр хүүхэд баримлыг хүлсэн, өөрөө бол юу гэж зөвшөөрөхөв, тэгтэл ийм юм болчихсон юм гэж бувтнажээ.

Лаборант Костя Шалаев уул нь энэ сургуулийг төгссөн, жирийн гэр бүлээс гаралтай, мэдлэг нимгэн ч хичээнгүй залуу. Алевтина Федоровна түүнийг харж үзээд, нэг хоёр жилийн дараа химийн дээд сургуульд орно гэж бодож, сургуулийнхаа химийн лабораторид үлдээсэн юм. Гэтэл Костя гэр бүлтэй болж, дээд сургуульд орохоо болиод лаборант чигээрээ үлджээ. Тэрээр дөнгөж орлогч гишүүн болсон залуу коммунист, намын хатуужил суугаагүй гэдгийг харгалзаж үзэхийг хүсээд, өдөржин лабораторидоо суухын оронд сургуулийн бүхий л ажлыг илүү сонирхож байх ёстой байсан байх, энэ бол өөрийнх нь буруу, гэхдээ л түүний туршлага суугаагүй, ажилчны гаралтай, засрах амлалт өгч байгаа энэ тэрийг харгалзаж үзэхийг дахин хүсье хэмээжээ.

-За, ямар асуулт байх вэ? гэж дарга цаасаа харан асуув.

Хөлөө ачин, цонхны тавиур тохойлдон сууж буй нөгөө царайлаг залуу ам нээж,

-Алевтина Федоровна, та Павел Павлович Устиновыг таних уу? гэв.

-Танина.

-Тодруулж ярьж болохсон болов уу?

-Хэлэлцэж байгаа асуудалд энэ ямар хамаатай юм бол? гэж Алевтина Федоровна асуув.

Дарга толгойгоо өлийж,

-Нөхөр Смирнова, та намын хянан шалгах комиссын хурал дээр байна, бүх асуултад хариулна шүү гэв.

-1921-1927 онд бид ЗСБНХОУ-ын Ардын гэгээрлийн комиссариатад цуг ажиллаж байсан.

-Дараа нь? гэж нөгөө царайлаг нөхөр асуув.

-Дараа нь намайг энэ сургуульд шилжүүлсэн, тэр комиссариатдаа үлдсэн, хожим нэг мужид ардын боловсролын хэлтсийн эрхлэгчээр томилогдсон.

-Та түүнтэй танилын холбоотой байсан уу?

-Москвагаас явах хүртэл нь холбоотой байсан.

-түүнийг ардын дайсны хувьд баривчилсныг та мэдэх үү?

Алевтина Федоровна чимээгүй азнаснаа,

-Мэднэ гэж хариулав.

-хэнээс мэдээв?

-Энэ тухай “Правда”-д гарсан.

-За тийм байж. Тэгвэл та Григорий Семенович Гинзбургийг мэддэг байсан уу?

-Мэддэг байсан. Тэр ч бас ЗСБНХУ-ын Ардын гэгээрлийн комиссариатад ажиллаж байгаад Москвагийн ардын боловсролын хэлтэст шилжсэн.

-түүнийг ардын дайсны хувьд баривчилсныг та мэдэх үү?

-Мэднэ.

-хэнээс мэдээв?

-Тэр бол Москвагийн ардын боловсролын хэлтсийн ажилтан, түүний баригдсан тухай Москвагийн бүх багш нар мэднэ.

-Та түүнтэй холбоотой байсан уу?

-Үгүй, хувийн харилцаа байгаагүй. Албан ажлаар, семинар, их хурал энэ тэр дээр тааралдаж байсан.

Ийнхүү Алевтина Федоровнагийн таньдаг, ардын боловсролын хэлмэгдсэн арваад ажилтны нэрийг дараалан асуув.

Энэ царайлаг этгээд ДЯАК-ын хүн юм байна, Алевтина Федоровнад хэрэг “нааж” байна, түүний ингээд балрах юм байна гэдэг нь Нинад тодорхой болов. Ер нь бүгдээрээ балрах нь, юуны өмнө Нина өөрөө. мань хүн Алевтина Федоровнаг өмгөөлсөн юм чинь... Шоронд орох уу? Яасан гэж?

Яг ингэтэл, нөгөө царайлаг этгээд бодлыг нь таасан мэт,

-Надад Ивановагаас асуух юм байна гэв. -Нөхөр Иванова та сурганы дээд төгссөн. Танай төгсөлтийнхөн бүгдээрээ орон нутаг руу явцгаасан. Та ямар аргаар Москвад үлдэж, өөрийнхөө төгссөн сургуульд буцаж ирсэн юм бэ?

Үнэнийг хэлнэ! Зөвхөн үнэнийг л хэлэх ёстой! Ганц ч худал үг, ганц ч булхай байж болохгүй. Гэвч Нина догдолсондоо болоод хоолой нь зангиран, эхний үгээ хоёр ч удаа давтаж байж зүгшрэв.

-Ийм учртай юм. Би Москвад байртай, тэр үед би бага насны дүүгээ асарч байсан юм. Бид хоёрт аав, ээжийн аль нь ч байхгүй. Энэ тухайгаа би төгсгөлтийн дараах хуваарь хийх үед

сургуульдаа учирласан юм. Тэгтэл Москвагийн аль нэг сургуулиас авна гэсэн бичиг авчирвал тийш нь томилолт өгч болно гэж надад хэлсэн. Надад Алевтина Федоровна тийм бичиг хийж өгсөн юм.

-Тэгвэл түүний хүсэлтээр таныг энэ сургуульд томилсон болох нь ээ?

-Тийм.

-Бас таныг намд элсэхэд батлан даасан уу?

-Тийм.

-Хоёрдахь батлан даалтыг?

-Иван Григорьевич Будягин.

-Ардын комиссарын орлогч байсан уу?

-Тийм.

-түүнийг ардын дайсны хувьд баривчилсныг та мэдэх үү?

-Мэднэ.

-Та хоёр яаж танилцсан юм бэ?

-Охин нь манай сургуульд сурч байсан юм, бид хоёр нэг ангийнх.

-Та түүнтэй уулздаг уу?

-Үгүй. Эцгийг нь баривчилсныг дуулснаас хойш би түүнтэй уулзах, ярилцахаа больсон.

-Таны батлан даагч ардын дайсны хувьд баривчлагдсаныг намынхаа байгууллагад илтгэсэн үү?

-Үгүй.

-Яагаад?

-Энэ тухай илтгэх хэрэгтэй юм гэж мэдсэнгүй. түүний батлан даалт миний хувийн хэрэгт байгаа.

Алевтина Федоровнагийн махлаг дугариг царайд хүний урманд ганц эд эс ч хөдөлсөнгүй. Нина нүднийхээ булангаар үүнийг мэдэрч, сэтгэл нь уужраад явчихав.

-Тэгвэл таны найз нөхдөөс өөр хэн баригдсан бэ?

Нина дал мөрөө хавчив.

-Мэдэхгүй. Өөр хүн юу л бол...

-Та тэгж нотлож байна уу?

Нина дахин дал мөрөө хавчив.

-Та яагаад дуугарахгүй байна?

-Та хэнийг хэлээд байгааг би мэдэхгүй байна?

-Би таны анд нөхөр Александр Павлович Панкратовын тухай ярьж байна.

-Панкратов ий? Бид нар бас нэг ангид сурч байсан... түүнээс хойш хэдийнэ арван жил өнгөрөөд байна.

-Тэгвэл түүнээс хойш уулзаагүй юм уу?

-Уулзалдаж байсан. Бид нэг байшингийнх. Гэхдээ тэр баривчлагдаж, Москвагаас цөлөгдсөнөөс хойш гурван жил болж байна.

-түүний баривчлагдсаныг та юу гэж үзсэн бэ?

-Юу ч гэж үзээгүй. Юуны учир баригдсаныг би тэгэхэд ч мэдэх-гүй байсан, одоо ч мэдэхгүй.

-түүнийг суллуулах гэж та хүсэлт гаргаж байсан уу?

Нинагийн зүрх оволзоод явчих нь тэр. Яасан санаандгүй асуулт вэ. Ямар захидлын тухай энэ асууж байна? Нөгөө сургууль дээр гарын үсэг зуруулах гэж байсныг уу?

Алевтина Федоровна түүнийг урж хаясан. Эсвэл нөгөө Ленагийн бодоцгоож байгаад, Будягины битгий явуул гэхээр больсныг уу? Эхнийхийг ганцхан Алевтина Федоровна л мэднэ, тэр хэнд ч ярих ёсгүй. Хоёрдахийн тухайд Лена, Макс, Вадим гурав мэднэ, бас Иван Григорьевич өөрөө мэдэж байсан, гэхдээ тэр захидлыг явуулаагүй... Гэтэл энэ этгээд санаандгүй асуугаагүй шүү дээ... Ямар нэг юм мэддэг байх.

-Би хааш нь ч, ямар ч хүсэлт гаргаагүй гэж Нина итгэл муутайхан хэлэв.

Энэ бол үнэн зүйл. Тэрээр намаа хуурч мэхлээгүй. Хааш нь ч, ямар ч хүсэлт явуулаагүй юм чинь.

Алевтина Федоровнагийн царайд бас л нэг ч эд эс хөдөлсөнгүй.

Дараачийн асуултыг Нина төсөөлж байв. Дотоодыг хамгаалахынхан түүний тухай ийм их юм мэддэг, тэр ч атугай, Сашагийн баригдсаныг юу гэж үзсэн ийг асууж байгаа юм бол, түүний тухай мэдээлэл цуглуулж, айл хөршийнхөнтэй нь хүртэл уулзсан гэсэн үг, тэгэхээр нөгөө өлөгчин Вера Станиславовна Варягийн орны дээр Сашагийн гэрэл зураг байдгийг гарцаагүй ховлосон байгаа. Варягаас болж ямар нэг хэрэгт холбогдоно гэдгээ мэдээд,

мэдрээд байсан шүү дээ. Энэ зургийн тухайд одоо юу гэж хэлэх вэ? Үнэнийг хэлж болохгүй, хэлэнгүүт Варяг бас зуураад авна. Эцгийнх нь залуугийн зураг гэх маягаар худлаа хэлэхээс өөр аргагүй. Гэтэл Варя тэр хоёрыг ажил дээрээ байх хооронд Вера Станиславовна хэсгийн төлөөлөгчид хаалга онгойлгож өгөөд, нөгөөдүүл нь Сашагийн зурагны зургийг авчихсан байвал яана? Тэгсэн бол мань коммунистыг районы намын хороон дээр, Алевтина Федоровнагийн дэргэд, Юферов, Яков Иванович энэ тэрийн дэргэд худлаа хэлснийг нь яг одоо илчлэнэ. Тэгж шившгээ дэлгэснээс газар доогуур орсон нь дээр!

-Надад өөр асуулт байхгүй гэж царайлаг этгээд зарлав.

Нина сандал дээр лагхийн сууж, нүдээ таглав.

-Ингээд дуусах тийшээ хандъя хэмээн дарга ам нээв. -Боловсон хүчнийг шилж сонгоход улс төрийн бүдүүлэг алдаа гаргасан, залуу үеийн марксч, ленинч хүмүүжлийг мушгин гуйвуулсан, ахлах ангийнхны зарим сурагчдад хувьсгалын эсэргүү, зөлөлтийн эсрэг авир гаргах боломж олгосон болон түүнээ нуусны учир, түүнчлэн ардын дайснуудтай-гээд нөгөө залуугийн түрүүн нэрлэсэн бүх нэрийг давтан хэлэв. -холбоотой байсны учир Алевтина Федоровна Смирноваг БХК(б)Н-ын гишүүнээс хөөж, сургуулийн захирлын ажлаас халах санал байна. хэн зөвшөөрч байна?

Комиссын гишүүд “зөвшөөрсөн” санал өгцгөөв.

-Санал нэгтэй шийдлээ гэж дарга өгүүлээд, -Смирнова, намын батлахаа тушаа! гэв.

Алевтина Федоровна бодолхийлснээ цүнхнээсээ батлахаа гаргаж, дахин нэг бодосхийгээд, уруулдаа хүргэж үнссэнээ батлахаа ширээн дээр тавив.

Энэ санаандгүй үйлдлээс болж хормын төдийд уймарцгааснаа дарга хамгийн түрүүнд сэхээ авч,

-Иргэн Смирнова, та явж болно гэж хөмсөг зангидан өгүүлэв.

Алевтина Федоровна хурлын өрөөнөөс гарав.

-Ивановагийн хэргийг салгаж, намын мөрдөгчид шилжүүлэх хэрэгтэй гэж бодож байна гэж царайлаг залуу хэлэв.

Тэрээр хөндлөнгийн хүн царайлан, ганцаараа цонхны тэндэх буланд сууж байгаа ч хэрэг дээрээ эндхийн гол этгээд гэдэг нь тодорхой байв.

Дарга толгой дохив:

-Нина Ивановна Ивановагийн хэргийг салгаж, намын мөрдөгчид урьдчилан хянуулахаар шилжүүлэх санал байна. хэн зөвшөөрч байна?

Бүгд “зөвшөөрч” санал өгцгөөв.

-Санал нэгтэй шийдлээ хэмээн дарга дүгнэснээ дахиад цаас руугаа харав. -Одоо Василий Петрович Юферов, Яков Иванович Маслюков, Константин Ильич Шалаев нарын тухайд...

Дарга түр азнав.

Царайлаг залуу дуугарсангүй.

-За тэгвэл, сонор сэрэмж хангалтгүй байсныг нь анхааруулья гэж бодож байна. Өөр санал байна уу? гэж дарга асуув.

Өөр санал гарсангүй.

-Шийдлээ, хурал дууссаныг мэдэгдье.

Районы намын хорооны байшингаас бүгд гарцгаав. Оройн таван цаг дөхөж нэгэнт бүрий болжээ.

-За энэ дээ! гэж Василий Петрович хэлээд “Смоленская” метро руу зүглэв.

Яков Иванович, Костя-лаборант хоёр сургууль руугаа очихоор шийдэж Глазовын гудам руу эргэв.

Нина тэднийг далд ортол хүлээзнэж байгаад Зубовын талбай руу харайлгав. Алевтина Федоровна Кропоткины гудамжинд аж төрдөг юм. Нина ямар ч байсан түүнтэй уулзаж, сэтгэл тайтгаруулах юухан ч бол хэлэх ёстой байв. Ямар муухай юм болов оо. Өөрөө яах вэ, юу хийх вэ гэдгээ бас зөвлөлдөх хэрэгтэй.

Тэрээр Кропоткины гудамжинд гүйж хүрээд зүүн тийш эргэснээ, зөн билгээрээ зогтусч, хана налав. Явган замын хажууд байгаа нэг хөнгөн тэрэгний дэргэд нөгөө царайлаг залуу, Алевтина Федоровна, үстэй захтай савхин дээлтэй өөр нэг хүн гурав зогсоцгоож харагдана. Царайлаг залуу албаныхаа үнэмлэхийг Алевтина Федоровнагийн нүүрэн тус савчин баахан юм хэлж байснаа, савхин дээлт тэр хоёр түүнийг хөндлөнгийн нүдэнд өртөмгүй, овсгоотой эвлэгхэн хөдөлгөөнөөр машинд түлхэн оруулаад, өөрснөө хоёр талд нь сууваас сайхь машин тэндээ дүрэм зөрчин эргэж, Кропоткины гудамжаар хотын төв рүү хурдлан одох нь тэр.

Нина гэртээ иртэл Варя байж таарав.

Яасан заяагүй юм бэ! Нина ганцаараа хэсэг байж, бүгдийг эрэгцүүлж бодъё, бүгдийг нягтлан тунгаая гэж бодож явжээ. Уймарч балмагдсанаа, а й д а с т автсанаа Варяд харуулахгүй гэсэндээ тэр.

Варя бахь байдгаараа орон дээрээ юм уншаад хэвтэж байв.

“Өдөржин хөл дээрээ зогсдог болохоор тулах эрхтэнээ амраах хэрэгтэй” гэж үүнийгээ зөвгөдөг юм.

-Өнөөдөр юу болоод чи ийм эрт ирээв?

-Хичээл орсонгүй. Юу гэж?

-Юу гээ ч үгүй ээ, зүгээр л асуусан юм.

-Шөл, төмс энэ тэр юун дор байгаа шүү гэж Варя хэлэв.

Бүр хоол хийчихэж!

-Юм идмээргүй байна гэж Нина хариулав.

Тэрээр Варягаас буруу харж бичгийн ширээ рүүгээ суугаад хоёр гараараа нүүрээ таглав. Уул нь ганцаараа ингэж суугаад бодох сон. Гэвч худлаа сайхан загнаад буй Варя яриангүй саад болж байна.

-Чамд ямар нэг юм тохиолдоо юу? гэж Варя тоомсоргүй асуув.

-Яагаад чи тэгж санав?

-Царай чинь нэг л хачин байна.

-Миний бүх юм ёсоороо байгаа.

-Тэгж харагдахгүй л байна шүү.

Нина уцаарлан эргэж харав:

-Чи юу гээд шалаад байгаа юм, чи яах гээв?

-Асууж болдоггүй юм уу?

-Болно, гэхдээ битгий тохуурхаад бай.

Нэг хэсэг Варя дуугарсангүй, номын эргүүлж байгаа хуудас шажигнахаас өөр чимээ алга. Нинад энэ чимээ ч саад болоод, санаа бодол нь төвлөрч өгдөггүй.

-Танай сургууль дээр юу болчихоов?

Нина эргэж, Варя руу нүдээ бүлтийлгэв.

-Чи юуг хэлж байна?

-Чи, харин, яачихсан юм бэ? гэж Варя номоо харсан чигээр асуув.

-Чи яасан гэж санаав?

-хүн амьтнаас дуулсан.

-хэн, юу чамд яриав?

-хэн ярьсан нь чамд хамаагүй, харин надад юуны тухай ярьж болохыг чи өөрөө сайн мэдэж байгаа.

-Тэглээ ч гэсэн чамаас сонсмоор байна.

Варя толгойгоо сэгсрэв.

-Яасан дээрэлхүү янзын дуу вэ.

-Манай сургууль дээр юу болж байгааг би чамаас сонсмоор байна гэж Нина давтан хэлэв.

-Танай сургууль дээр районы намын хорооны комисс ажилласан. Заргын ховыг Туся Наседкина бичсэн гэсэн, тэр ч хэзээнээсээ хүний адаг л даа. Баримт... За, олон баримт бий гэсэн, би тэр болгоныг тогтоогоогүй. Сталины хамрыг холт цохьчихоод дараа нь хүзүүгээр нь дүүжлэсэн, хурал дээр түүнийг үхсэн гэж зарласан, гэтэл мань хүн, “ашгүй”, амьд байгаа. Дараа нь өөр юу билээ... Өө тийм, Алевтина Федоровна коммунист багш нарыг хөөж, оронд нь эргэлзээтэй, дайсагнасан этгээдүүдийг авч байсан. “Декамероныг” уншсан, бас Бальмонт, Игорь Северянин, товчдоо, элдэв эсэргүүнүүдийг уншуулсан.

-Гэхдээ хэн чамд үүнийг хэлээв?

-Энэ чамд хамаагүй гэж би түрүүн хэлсэн шүү дээ.

Варя босч, орон дээрээ суув.

Одоо тэр хоёр нүд нүд рүүгээ эгцлэн харж байна.

-Би чамд илүү ч юм хэлсэн болох байна. Чамайг бас тэр комиссынхон шалгаасан гэсэн. Тийм шүү. Сая чи районы намын хорооноос ирсэн. Тэнд юу болов? Ярь л даа! Чамайг намаас хөөв үү?

Нина дуугарсангүй. Бүгдийг мэдэж байна. Хаанаас олж мэдэв? Ингэхэд, хаанаас мэдсэн нь ямар хамаа байна? Гарцаагүй мэдэж.

Варя Нина руу эгцлэн харсан чигээрээ үргэлжлүүлэв:

-Би чамд худлаа хэлсэн юм. Манай хичээл ороогүй биш. Би зүгээр л сургууль руугаа очоогүй юм. Гэртээ ирээд чамайг хүлээж байгаа нь энэ. Юу болоод байгааг би мэдмээр байна. Чи чинь, ямар ч атугай, миний эгч шүү дээ!

“Чи чинь, ямар ч атугай, миний эгч шүү дээ!” Нина хэрдхийв.

Варя сайн ч, муу ч, цорын ганц мах цусны тасархай. түүнд өөр хэн бий билээ? Өөр хэн ч байхгүй, бүгд үрэгдэж элэгдсэн. Алевтина Федоровнаг баривчилсан, өөрийг нь өнөө маргаашгүй баривчлана. Варя, мэдээж, хөөцөлдөж харайлгана, гай зовлон тохиосон хүнийг зөнд нь орхидог хүн биш, гэтэл ямар ч хөөцөлдлөг хэрэг болохгүй, тэндээс тавина гэж байдаг зүйл биш. Ямар ч атугай Варя бүх юмыг мэдэж авах ёстой, түүнийг ч дуудаад байцааж мэднэ.

Зөвхөн Варя л өөрөөс нь няцах ч үгүй, орхих ч үгүй хэмээн Нина энэ олон жилд анх удаагаа бодов. Дүүгийнхээ дэргэд очиж, мөрөн дээр нь толгойгоо тавиад зэрэгцэж суух юмсан, хэдэн нулимс ч унагасан яахав, тэгээд амьдрал утга учиргүй нурж, дуусгавар болж байгааг хэлэх юмсан гэж санагдав. Баригдана гэдэг бол амьдрал дуусна, бүх юм дуусна гэсэн үг юм чинь.

Гэвч тэгсэнгүй. Хэдэн жилээр хуримтласан хүнийрхүү байдлаа гэтлэж чадсангүй, бас олон жилээр төлөвшсөн зан араншингаа ч давж чадсангүй. Тэгээд зөвхөн ингэж хэлэв:

-Тийм ээ, сургуулийг тэгж буруутгаж байгаа. Миний хувьд үүнээс гадна олон юм бий: намайг намд элсэхэд Иван Григорьевич Будягин батлан даалт гаргасан, тэр одоо баривчлагдсан, би энэ тухай намын байгууллагадаа мэдээлээгүй; би Алевтина Федоровнаг бүх асуудлаар дэмжиж байсан, намайг ажилд авсан хүн ч тэр; бас, Сашаг баригдах үед түүнийг хамгаалж захиа бичих гэж санаархсан гээд Нина хэсэг зуур чимээгүй болсноо, -Өнөөдөр районы намын хорооны хурлын дараа Алевтина Федоровнаг шууд гудамжнаас барьж аваад явчихсан, би маргааш намын мөрдөгч дээр очих ёстой. Одоо Алевтина Федоровна надад намд элсэх батлан даалт гаргасныг нэмж тулгана гээд аяндаа бүрхэн ирсэн нулимсаа арчив.

-Тэгж тулгачихаад л чамайг бас баривчлана гэж Варя хэлэв.

-Тэгнэ, чи тэр үед самгардах хэрэггүй шүү гэж Нина аяархан өгүүлэв.

Варя босч, өрөөн дотуураа хэд алхсанаа Нинагийн дэргэд очиж, мөрөн дээгүүр нь илэв.

-Битгий уйл. Хоюулаа нэг юм бодъё. Чи хэр мөнгөтэй вэ?

-Юу гэж?

-Чи хэр мөнгөтэй вэ?

Нина ширээний нүдэнд байсан мөнгө, түрийвгэй мөнгө хоёроо тоолов.

-Зуун арван рубль.

-Надад хоёр зуу бий, нийлээд гурван зуу гэсэн үг. Овоо шүү. Онц ч гэж болно. Хүрэлцэнэ. Одоо анхааралтай сонсож бай гээд Варя Нинагийн өмнө ирж зогсов. -Чи одоо ойр зуурын юмаа, гарцаагүй хэрэгтэй юмаа шүү, эмхэлж чемоданд хий, би чемоданыг чинь авч гараад “Смоленская” метроны тэнд хүлээж байя. Тэгээд хоюулаа Ярославлийн галт тэрэгний буудал руу очно, чи тэндээс Максим руу яваад өг. Чамайг вагонд суугаад, галт тэрэг хөдлөнгүүт би Максимд, чамайг тос гээд цахилгаан явуулчихна. Ойлгов уу? Юмаа эмхэл!

-Үгүй, үгүй, чи солиороо юу?

Варя түүний үгийг тасдав:

-Харин чи л солиорох нь! Чамайг барих гээд хэзээ ч ирцгээж мэднэ, өнөө шөнө ч магадгүй. Чи тэнэг юм уу, үнэхээр ойлгохгүй байна гэж үү?

-Гэхдээ... хэмээн Нина эсэргүүцэх гэж үзэв.

-Юуны чинь “гэхдээ?!” хэмээн Варя уурлав. -Чи Хетагурова шиг л явж байхгүй юү, ойлгож байна уу, Хетагурова шиг! Одоо охид бүсгүйчүүд цөм Алс Дорнод руу явцгааж байгаа, манай цэргийн дарга нарт авгай хэрэгтэй шүү дээ, тэгэхээр чи Макс руу авгай нь болоод явж очихгүй юү. Юу нь ойлгомжгүй байна аа?

-Байз, битгий хашгич л даа, яасан юм ойлгодоггүй хүн бэ? Маргааш өглөө би хичээлтэй гэж Нина царайчлангуй хэлэв.

-Мулгуу толгой! Хичээл гэнэ! Чамайг шоронд хийчихвэл хар машинаар хичээл рүү чинь зөөх юм уу?

-Гэхдээ би, үгүйдээн, намынхаа шилжүүлгийг авах ёстой.

-Цаадуул чинь чамайг зүгээр л шилжүүлээд өгөх үү?! Чамайг тавихгүй гэж мэд! Намын шилжүүлэг! Нохой долоо! Чиний тэр нам яав л гэж!

Варя босоо шүүгээ рүүгээ сандал тулгаж байгаад дээрээс чемоданаа өргөв.

-Май! Аваач! Авахгүй бол хаялаа шүү, байраар нэг нүргээн болно гэж мэдээрэй.

Нина чемоданыг авч, тэр чигээрээ өрөөнийхөө голд очоод зогсчихов.

Варя сандлаасаа үсэрч буугаад, чемоданыг шүүрэн авч, шалан дээр тавьж онгойлгоод, доторхийг нь хуу гаргаж хаяв.

-Өөрийнхөө новшнуудыг хий!

Гэтэл Нина дахиад ширээ рүүгээ очоод суучихав.

-Би жаахан бодох ёстой.

-Бод, бод гээд Варя шүүгээгээ нээж Нинагийн дотуур хувцас, даашинз энэ тэрийг чемоданд хийж эхлэв. -Сайн бод, одоохондоо амьд байгаа дээрээ сайн бод. Нүдээ сайн нээ, тэгээд эргэн тойронд юу болж байгааг хар. Манай байшингаас гэхэд л хичнээнийг шо-ронд хийчихээд байна даа. Гуравдугаар орцны зураач Вера Михайловна Сапожниковаг хүртэл барьсан. Сталины нүүрийг нөрөөтэй зурчихсан юм гэнэ. Сталин багадаа цагаан бурхантсан, нүүр нь цоохор шүү дээ, тэр хүүхэн нэг зурагнаас хуулж зурсан гэж байгаа, гэтэл тэр нөрөөний төлөө түүнд найман жилийн ял наачихсан. Хүүхдүүд гадаа, “Ленин нас нөгчсөн, Надежда үлдсэн, Сталин амьд байна, Надежда алга болчихсон” гээд дуулцгаагаад байсан. Тэд чухам юун Надежда, яасан Надежда гэдгийг ойлгохгүй хэрнээ хэн нэгнээс сонсоод түрэн авч, гүйх харайхын зуурт, “Ленин нас нөгчсөн, Надежда үлдсэн, Сталин амьд байна, Надежда алга болчихсон” гэж хашгиралдаж явах... Гэтэл нөгөөдүүлийг чинь шүүрээд эхэлсэн. Арван дөрвөөс дээш настайг нь аль хэдийн шоронд хийчихсэн, бусдыг нь сургууль дээр элдэнг нь хангаж, эцэг эхийг нь ДЯАК руу байнга дуудаж байна. Зохион байгуулагчид, турхирагчид, хэн заасан, хэн эхлэж дуулсан энэ тэрийг хайж байна. Чиний нөгөө хамгийн мундаг коммунистуудыг буудан алж байна. Чиний Алевтинаг шоронд хийчихлээ. Гэтэл чи хэн билээ? Хорхой шавьжийн төдий амьтан, шоронд хийгээд л буудаж ална. Өөрийгөө тоодоггүй юм гэхэд бусдыг өрөвд. Лубянкад аваачаад тарчлаана шүү дээ. Иван Григорьевич, Алевтина Федоровна хоёрын талаар, чиний бүх танилуудын талаар, багш нарын талаар, хөөрхий муу Ирина Юльевнагийн талаар мэдүүлэг өгөхийг шаардана. Чи хэн хэлснийг мэдэх гээд байсан, тэгвэл Ирина Юльевна л надад хэлсэн юм, хэлсэн нь ч зөв.

Варя чемоданаас түр хөндийрч Нина руу харав.

Цаадах нь шал шагайн сууж байна.

-Алевтинаг шоронд хийсэн юм бол танай сургуулийг “үүр” гэж зарлана шүү дээ. Сонинд “Хорлон сүйтгэгчид, үл бүтэх этгээдийн үүр” гэж яг бичнэ. Чамайг шар махтай чинь хатаана гэж мэд, бүх юманд албадаж гарын үсэг зуруулна, гэм буруугүй өөр олон хүнийг чамаас болж шоронд хийнэ. Чиний гоёлын шаахай чинь хаана байна? А-хаан... хэмээснээ орон доогуураас зуны хувцас хунартай сагсаа гаргаж ирэв. -Тэнд чинь элдэв үдэшлэг энэ тэр болж таарна, бодвол Улаан Армийн ордон бий байлгүй гэв.

-Өнөө шөнө намайг барих гэж ирвэл чи юу гэж хэлэх юм бэ?

-Өнөөдөр ирэхгүй гэж бодож байна, чамайг маргааш нэг газар ир гээ биз дээ. Гэтэл чи очихгүй. Тэгээд л чамайг хайж эхлэнэ. Би тэгэхэд нь, “Ёстой хүний урманд мэдэх юм алга, бид хоёр муудалцаж дуугарахаа байсаар хагас жил болж байна, хаана байгаа, ямар юмтайгаа нөхцөж явдгийг би мэдэхгүй” гэж хэлнэ. Ер нь тэд нар ирэхгүй дээ. Чамайг сургуульдаа ч ирээгүй, районы намын хороон дээр ч очоогүй гэж мэдмэгц бие нь муудаж гэж санана, тэгээд зугтсаныг чинь ухаарч ядаж байх хооронд чи аль хэдийн Макс дээр оччихсон байна, харин ирэнгүүтээ гэр бүлийн товчоон дээр очиж бүртгүүлээд Костина болчих. Ер нь цаадуул чинь чамайг эрж хайхгүй. “Нина Ивановна Иванова” нэртэй хүнийг Оросоос мөн олно доо!

Нина толгойгоо ганзагалсан хэвээр.

-Гэрийнхээ шахайг тайл, би өөр цүнхэнд хийчихье, вагонд орсон хойно хэрэг болно.

-Би хаашаа ч явахгүй, би намаасаа зугтааж чадахгүй. Тийм эрх байхгүй гэж Нина гэнэт зөрөв.

Варя бөхийн, түүний хөлөөс шаахайг нь мултлав. Цаадах нь эсэргүүцээгүй ч байрнаасаа хөдлөсөнгүй.

-Чи намаасаа зугтаж байгаа биш, шил рүү чинь тусах сумнаас зугтааж байна. Үхвэл чи намдаа ямар хэрэгтэй юм бэ?

-Тэглээ ч гэсэн би хаашаа ч явахгүй, ойлгож байна уу, би хаашаа ч явахгүй!

Варя босч, Нинагийн хоёр мөрнөөс базан сэгсэрсэнд толгой нь гэдэсхийв.

-Юу гэнэ ээ?! Явахгүй юү?! Тэгвэл өөрөө Лубянка руу оч. Очиж гэмш! Бусдыгаа илчил, тэдэн рүү хамаг буруугаа чих, тэднээсээ урван тэрсэл! Тэгвэл буудаж алахгүй, хорих лагерьт явуулж магад. Хэрвээ шивэгчин болвол бүр хорино, цөлнө гэж байхгүй. Яв, яв, очиж үүргээ биелүүл! Яв! Цаадуулыг чинь энд ирүүлэхийг би хүсэхгүй байна хэмээн түүнийг сэгсчсэнээ, өлгүүрээс пальтог нь авч,

-Яв! Май! Хувцасла! гээд шидэв.

-Байз, тайвшир, хоюулаа сайн бодъё гээд Нина дахиад ширээгээ тохойлдов.

Варя орон дээрээ сууж,

-За тэгье, сайн бодъё гэв.

-Би явлаа гэж саная, миний хэрэг гайгүй бүтлээ гэж саная. Гэтэл чамайг оролдоод эхлэнэ, чамайг зовоож гүйцнэ гэж Нина хэлэв.

Варя хямсалзан толгой сэгсрэв:

-Тэнгэр минь, ийм бодлоо толгойноосоо авч хая. хэн надаас асуух юм бэ? Асуулаа гэхэд би тэдний амыг таглаж чадна, чи битгий санаа зов. “Би энд чухамдаа амьдардаггүй. Хөршүүдээс асуу. Нөхөртэйгөө өөр газар сууж байсан. Энд хаа нэг л хонодог. Эгчтэйгээ юм дуугардаггүй, намайг хүнтэй суух үеэс бид хоёр муудалцсан. Өдөржин ажил дээрээ, орой нь сургууль дээрээ байдаг” гэж хэлнэ. Товчдоо, чи миний өмнөөс санаа бүү зов! Би танай сургуулийнхны явдлыг мэдэх ч үгүй, мэдэхийг ч хүсэхгүй байна. Уржнан зун чи нэг сар явчихсан, Ленинград руу дамжаанд явсныг чинь би тээр хойно дуулсан.

-Гэхдээ чи юуг... мэдэж байсан шүү дээ, юуг... хэмээн Нина эхлэв.

-хэн тэрийг чинь мэдэх юм бэ?! Зөвхөн чи бид хоёр л мэднэ. Тэд нарын хувьд бол, би чиний амьдралын тухай юу ч мэддэггүй, чи ч миний амьдралын тухай юу ч мэддэггүй байсан гэж Варя хашгичив. -Чи одоо ч гэсэн бас нэг дамжаанд явчихсан ч юм уу. Ер нь бол оо! Эрваатахаа больцгооё! Одоо чиний амьдрал шийдэгдэж байна. Ойлгож байна уу?! Амьд явах

уу, үгүй юу гэдэг чинь. Чамд яг өнөөдөр Макс руу явах ганцхан боломж байна. Маргааш энэ боломж алга болно, чамайг мөрдөж мөшгөөд эхлэнэ, тэгээд дор нь бариад авна.

-Тэгвэл өнөөдөр ч гэсэн мөрдөж байж мэднэ, тэгээд явж байгааг харчихвал бариад авна. Тэгсэн цагт ёстой дуусах нь тэр. Би зугтааж, нуугдах гэж байгаа бол үнэхээр буруутан гэсэн үг болно.

-Өнөөдөр чамайг мөрдөхгүй, битгий зов! Районы намын хорооноос гэр хүртэл чинь дагасан байж магадгүй, гэхдээ юу л бол, чи чинь тэндээс өөр зүг рүү гүйсэн гээ биз дээ. Бас одоо орой болчих-лоо, тэд нар чинь ч амрах ёстой. Тэднүүс биднийг анзаарна гэж бараг байхгүй, гэхдээ тэглээ гэж санахад чи бид хоёрын хэн нь явж байгаа нь бүү мэд шүү дээ. хүн хүрээд ирвэл би явж байгаа, чи үдэж өгч байгаа болчихно, ямар тасалбар дээр нэр байх биш. Гэхдээ энэ бүхэн мунхаг таамаглал, хэн ч биднийг мөшгөхгүй, чи амар жимэр яваад өгнө. Би чемодан аваад гарна, намайг хэн ч тоохгүй, чи арын хаалгаар гараад Сивцев Вражек, Денежный хоёрыг сүлжиж уруудаад метрон дээр очно. Ниночка, эгч минь, ухаар, тайвшир, тэр заяагүй намын хорооноос айхаа боль, би гуйж байна, тэндээс чинь өдөр өнжихгүй хүн баригдаж байгаа, айсандаа өөрснөө чичирч байгаа. Чухамхүү өөрснөө айж байгаа учраас л чамайг хөөж, шоронд хийлгэнэ.

Тэрээр чемоданаа хаав.

-Явахынхаа өмнө ганц халбага шөл ч болохноо ид.

-За яахав, таваглаад аль хэмээн Нина зөвшөөрөв. Өөрөө босч хоолоо таваглах тамир алга. - Олон зүйлийг чи зөв ярьж байна, гэхдээ бүх насаараа Костина гэдэг нэрийн дор нуугдаж, намын мөрдөнгөөс зугтсаныг мэдчихнэ, илчилчихнэ, мэдээлчихнэ гэж айж явах...

Варя толгой сэгсрэв.

-Алс Дорнодод хэн чамайг мэдэх юм бэ? Мэдсэн ч яадаг юм бэ, одоо тийшээ мянга мянган охид бүсгүйчүүл явж байгаа, чи тэдний нэг л байгаа биз. Хэрвээ гурав, дөрвөн жилийн дараа Москвад буцаад ирлээ гэхэд тэр үед чамайг бүрмөсөн мартана, чиний тэр районы намын хорооныхныг толгой дараалан шоронд хийх юм чинь. Нина минь, өөрийгөө аварч үз! Чамд Макс байгаа чинь ёстой аз. Чи түүнд хайртай шүү дээ, тэр ч чамд хайртай. Максыег чи Любянкийн шоронгийн өрөөгөөр, шилэндээ зоолгох сумаар, хорих лагераар солих юм гэж үү? Наад хоолоо боль, хувцасла, явцгаая!

Нина түүнийг гунигт харцаар ширтэн бослоо:

-Нээрэн, чиний зөв, явахаас яахав. Хэсэг хугацааны дараа энэ жудаггүй, замбараагүй байдал дуусна, тэр үед миний хэргийн учрыг тайван олно биз.

-Яг зүйтэй хэмээн Варя дэмжив.

Ирээдүйд ч олигтой юм болох царай алга гэж хорон үг хэлэх гэсэн боловч Нинагийн дургүйг дахин хүргэхгүйн учир Варя юм дуугарсангүй. Үгэнд орсон нь л яамай.

Замд элдэв юм тохиосонгүй. Нина арын хаалгаар гарч, Сивцев Вражек, Денежный хөндлөн гудмаар явсаар метронд ирэхэд, Варя тасалбарын цонхны хавьд чемоданаа хөлөөрөө хана руу шахаад зогсож байв. Хүмүүс яаран шахцалдаж, зарим нь автомат утсанд оочерлон овоорч, ярьж байгаа нэг нь чанга чанга хашгичиж, нөгөөдүүл нь түүнийг яаруулан байх бүлгээ.

Танил дасал ч гэсэн сэтгэлд ямар нэг түгшүүр төрүүлдэг оройн Москвагийн энэ их хөл үймээнийг хараад, Нинагийн сэтгэл дахин хоёрдов. Варяг ганцааранг нь орхиж байна, өөрийнх нь өмнөөс хариуцлага хүлээхээр, аягүй бол, төлөөнөөсөө зовлон эдлүүлэхээр орхиж байна, яаж шуу мултардаг юм бол доо?

Варя чемодан руугаа тонгойтол эгч нь гараас нь барьж авав.

-Варюша... Ингэхэд... Бид хоёр зөв юм хийж байна гэж чи итгэлтэй байна уу?

-Ээ, тэнгэр минь! хэмээн Варя бухимдав.

-Чи бид хоёр ингээд хэзээ ч уулзахгүй бол яана?

-Өнөөдөр чи галт тэргэнд сууж чадахгүй болвол л бид хоёр хэзээ ч уулзахгүй болно. Бид гэр рүүгээ буцаж болохгүй, яг орцны үүдэн дээрээс биднийг урхидаж мэднэ. Чи үүнийг даанч ойлгохгүй байна гэж үү?

Нина чимээгүй бодолхийлснээ,

-За яахав, явцгаая гэж хэлэв.

Тэд доошоо бууж, оройн арван цаг өнгөрч байхад Ярославлийн буудал дээр ирцгээв.

Москва-Хабаровскийн галт тэрэг явахад нэг цаг үлджээ. Дараачийнх нь маргаашийн мөн цагт явна. Тийз, мэдээж, байхгүй.

Варя буудлын жижүүр дээр очиж, өнөөдөр Москвагаас Хабаровск руу найман цагт хөдлөсөн хетагуровчуудын тусгай галт тэрэгнээс хоцорчихлоо гэж залав. Ээж нь өвчтэй байснаас болоод

хожигдсон, бүх бичиг баримт нь тэр цуваагаар явчихсан, түүнийг гүйцэхээс өөр замгүй гэж. Шургуу, биерхүү, сайхан бүсгүйд итгэхээс яахав, ажилдаа сульдаж үүлгэртсэн жижүүр ямар нэг хуваарь харж байснаа нөгөө цуваанд шилжиж суухын тулд энэ буухиа галт тэрэгнээс ямар өртөөн дээр буухыг хэлж өгөв. Тэр өртөө хүрэх тасалбар түүнд өгөх юм байж.

-Цувааны галт тэрэг тийшээ түрүүлж ирвэл яахав? Тэгээд надгүй явчихвал? Би тэгвэл хаачих вэ? Больё, чи минь, надад Хабаровск хүртэл л тасалбар өгчих.

-Та тийм их мөнгө төлөх хэрэг юу байна? гэж жижүүр гайхан асуув.

-Сэтгэл амар байхгүй юу. Бусад бүсгүйчүүл хэн рүү очихоо мэдэхгүй явж байгаа, би бол мэднэ, миний сүйт залуу тэнд бий, намайг хүлээж байгаа, хошууч хүн, тасалбарын үнэнд

хотойхгүй.

-Дураараа болж дээ гэж жижүүр хэнэггүй өгүүлээд түүнийг дагуулан явж тасалбар авч өгөв.

Эгч дүү хоёр нийтийн вагонд орж, суудлаа олж чемоданаа тавиад түр сууцгаан аяархан ярилцав.

-Очингуутаа Төв холбоо руу, өөрөө авагч гээд цахилгаан явуулаарай. Захиагаа ч бас өөрөө авагч гэж бичнэ шүү гэж Варя хэлэв.

-Би маргааш ч аль нэг том өртөөнөөс цахилгаан явуулсан болно.

-Бачимдаад яахав, бүх юм болж бүтнэ, очсон хойноо л явуулаарай.

-Гэхдээ чи холбоогоор орж байгаарай, чиний ажлаас холгүй юм чинь. Бас шуудангаар ч орж байгаарай, би замаасаа ил захидал хийчихэж магадгүй шүү.

Нина нэг шийдвэл тайвширчихдаг хүн, одоо ч тайван байна. Варяд хэлээгүй, гэхдээ намынхаа батлахыг хаяхгүй, Максимын намын байгууллагад очиж бүртгүүлнэ, Москвагаас бүртгэлийн картаа шаардуулж авахуулна, тэгээд хэргийнх нь учрыг Хабаровскт олно биз гэж дотроо шийдсэн ажээ. Чухамхүү энэ бодолдоо тайвширч, итгэл орсон юм байж. Бас энэ рүү гайгүй ирж, тасалбар олоод галт тэргэнд суучихсандаа ч тайвширч. Гэхдээ жаахан бачууралгүй яахав.

Тэгж байтал үйлчлэгч хүүхэн галт тэрэг хөдлөх гэж буйг зарлан, үдэж байгаа хүмүүсийг вагоноос гарахыг хүсэв.

Эгч дүү хоёр босч тэврэлдлээ, үнсэлцлээ, нулимс унагацгаалаа. Сүүлийн удаа тэд хэзээ үнсэлцсэн билээ? Ер нь үнсэлцэж байсан бил үү? Хүүхэд ахуйдаа магадгүй юм даа.

-Чи цонх руу битгий ойртоорой гэж шивнээд Варя вагоноос гарлаа.

Шүглийн дуу тасхийж, галт тэрэг зугуухан хөдлөхөд Варя

өөрийнх нь тооцоолсноор Нина хажууд нь сууж байх ёстой цонх руу хэсэг харахад, тэндээс хэн нэгний царай бүүдийсээр далд оров.

Ярославлийн буудлаас цахилгаан явуулахад аюултай санагдсан тул, Варя Ленинградын буудлаас Максимд цахилгаан илгээв.

Оржоникизе тохиролцсон ёсоор өдрийн гурван цагт Кремльд, Сталин дээр ирэв. Өөрийнхөө салбарын сүүлийн үеийн сониныг товчхон мэдээлэв. Гэхдээ хүйтэн хөндий царайлж, бүх юм номоороо байгаа, хэрвээ аж үйлдвэрийн салбарын удирдах ажилтнуудыг үндэслэлгүй хэлмэгдүүлээгүй бол улам ч сайн байх байсан гэх аястай ерөнхий зүйл ярьжээ.

Сталин Бериягаас ирсэн цахилгааныг түүнд өгөв.

Балахнинскийн газрын тосны үйлдвэрлэлийн нэг хэсэгт гарсан ослыг хүнд аж үйлдвэрийн ардын комиссариатын удирдлага нуун дарагдуулсан тухай тэр цахилгаанд өгүүлжээ.

Оржоникизе Сталин руу гайхшран харав.

-Энэ чинь юун осол вэ? Хэзээ?

-Наана чинь байгаа гээд Сталин цахилгаан руу дохив.

Оржоникизе гүйцээж уншаад Сталин руу дахин гайхширч харав.

-Үгүй, энэ чинь ноднин зургаан сард, өөрөөр хэлбэл зургаан сарын өмнө гарсан осол. Хор уршгийг нь тэр даруй арилгасан жижигхэн осол. Муу үл бүтэх өдөөн хатгагч! Би тэр муугийн тухай ярихыг ч хүсэхгүй байна гээд мань хүн цахилгааныг базаж, ширээ шаагаад, -Харин Папулия ахтай минь уулзуулаад аль! гэв

-Цахилгаанаа тавь.

Оржоникизе цахилгааныг ширээн дээр шидэв.

Сталин түүнийг авч тэнийлгэв.

-Ингэж догдлохын хэрэг юу байна, ялангуяа зүрх муутай хүн... Бүгд хурал дээр тавих илтгэлийн чинь сэдэв бэлэн болсон уу?

-Үгүй!

Оржоникизе нитроглицериний үрэл хэлэн дороо хийв.

-Хэзээ бэлэн болохов?

-Мэдэхгүй.

-Бүгд хурал хоёр өдрийн дараа нээгдэнэ, хойшлуулж болохгүй, бүх илтгэгчид сэдвээ өгчихөөд байна.

-Бэлэн болохоор нь өгнө. Хэрвээ би өөрөө шаардлагатай гэж үзвэл өгнө. Би-Улс төрийн Товчооны гишүүн, юу ярихаа шийдэх эрх надад бий. Ежовоор сайшаалгах шаардлага надад

байхгүй.

Сталин чимээгүй байзнаснаа ингэж хэлэв:

-Тийм ээ, чи Улс төрийн Товчооны гишүүн, тэгэхээр Товчоон дээр санал бодлоо хэлж чадна. Харин ТХ-ны Бүгд хурал дээр бол Товчооны үзэл бодлыг, намын удирдлагын үзэл бодлыг чи илэрхийлэх ёс т о й. Эс тэгвээс чи өөрийгөө Улс төрийн Товчооны сөрөг хүчин, намын удирдлагын сөрөг хүчин болгоно. Эс тэгвээс чи өөрийгөө намын эсрэг сөргүүлэн тавьж байгаа хэрэг. Тийм шийдлийнхээ үр дагаварын талаар тогтож бод. Чамаас өмнө өөрсдийгөө намын эсрэг сөргүүлэн тавихыг оролдсон хүмүүсийн туршлагыг бодолц. Тогтож бод! Гэртээ харьж тайвшир, тэгээд тогтож бод. Тайвшрахаар чинь ярилцъя.

Оржоникизе босч, сандлаа түр тархийлгэн холдуулав.

-Бүгд хурал дээр ярилцана аа.

Тэгж хэлээд хаалга саван гарч одов.

Гуч, дөчин минутын дараа Молотов, Каганович, Ворошилов, Микоян, Жданов нар ирцгээв. Бүгд хурлын бэлтгэл болон цаг үеийн асуудлаар ярилцацгаав.

Поскребышев үүд нээлээ.

-Нөхөр Сталин! Тантай Зинаида Гавриловна Оржоникизе утсаар ярья гэнэ.

-Яах гэв тэр чинь?

-Григорий Константинович нэг юм болсон гэнэ.

Сталин толгой сэгсрэв.

-Сая л энд хараал зүхэл тавиад, үрэл үмхлээд байсан юм. Зүрхээ бод гэж би хэлсэн. Тун бодъё гэхгүй байгаа хүн. Аягүй бол, дахиад өвчин нь хөдөлсөн дөө.

Утсаа авав:

-Сонсож байна... Юу?! Битгий донгос! Гар бууг нь хол, далд байлгахгүй яасан юм бэ! Битгий балай юм донгос, дахин хэллээ шүү! Одоо очлоо. Эмч би дуудна.

Тэрээр утсаа тавьж, нөгөөдүүлийгээ бэрх харцаар тойруулан харав.

-Серго өөрийгөө буудчихаж.

хэн ч дуугарсангүй.

Сталин өөр нэг утсаа авлаа.

-Нөхөр Ежов! Нөхөр Оржоникизе өөрийгөө буудчихжээ. Бушуухан эмч нар ирүүл. Амийг нь аварч чадахгүй бол эрүүлийг хамгаалахын ардын комиссар Каминскийг над руу ирүүл.

Сталин харилцуураа барьсан чигээрээ хэсэг болсноо,

-За яахав, очиж харцгаая, юу гээч болчихсон юм бол гэж өгүүлэв.

Тэднийг гарахад эмнэлгийн машин хажуугаар нь сүрхийн өнгөрч Оржоникизегийн орцны үүдэн дээр зогсов. Машинаас цагаан халаадныхаа гадуур энгэр задгай пальтотой хэдэн хүн ухасхийн гарч, орц руу гүйлдэн орцгоолоо.

Сталин алхаагаа саав:

-Эмч нарт саад болоод яахав.

Бүгдээрээ алхаагаа саацгаав. Бас хэн нь ч ам нээсэнгүй.

Шагаар мөн зугуухан өгсөцгөөв. Байрны үүд онгорхой байна.

Серго унтлагынхаа өрөөний орон дээр хэвтэж байна. Толгойн тус газар Зинаида Гавриловна хөшсөн мэт зогсож харагдана. Тэрээр энэ хүүхнийг олон жил мэдэх бөгөөд Сергогийн сонголтыг байнга гайхдаг билээ. Өөрөө ямар сайхан толиотой эр билээ, гэтэл Сибирийн хаанаас ч юм бэ, нэг тосгоны багштай гэрлэсэн байгаа юм. Үзэх царайгүй, номхон, нунжгар энэ хүүхний юунд нь Серго шунадаг байна аа? Хүүхэн Сталин руу бэргэн харснаа уруулаа хазав.

Орны дэргэд эмч, сувилагч нар миегнэлдэн, шал арчиж, орны даавуу энэ тэрийг сольж байв. Цагаан халаадтай жижигхэн хар хүн тэдний ажлыг хянаж, юу хийхийг нь толгой дохин зааварлаж байна. Гар буу хэвтэж байгаа сандал руу дохиж, -Холдуул! гэв. Гэтэл Сталин бууг авч, сойлтыг нь шалгачихаад халаасандаа хийчихэв.

Эмч сувилагч нар ажлаа дуусгаад орноос холдлоо. Дутуу бүтээсэн Серго атгасан гараа хөнжил дээрээ сул тавиад гэдэргээ хараад хэвтэж байна.

Цагаан халаадтай хар царайт Сталин руу асуух янзтай харлаа.

-Яаж вэ? гэж Сталин асуув.

-Хагас цагийн өмнө нас барсан байна гэж хар царайт цэргийн ёсоор тод хариулав.

Сталин тэнд байгаа хүмүүсийг баргар царайлан тойруулж хараад,

-Өвчтэй зүрхээ боддоггүй, эмч нарын зааврыг биелүүлдэггүй бол ийм болдог байна гэж өгүүлэв.

Энэ үгийг, юуны өмнө, эмнэлгийнхэнд зориулан хэлжээ. Нөхөр Оржоникизе зүрхний өвчнөөр нас нөгчсөнийг бүгд мэдэж авах ёстой. Өөр ямар ч таамаг байх ч ёсгүй, байлгах ч

ёсгүй.

-Одоо яв! гэж Сталин хар царайтад тушаал өгөх зуур Зинаида Гавриловна руу цоргин харахад цаадах нь харцаа буулгав. -Задлан хийхгүй гэж дарга нартаа илтгэ. Бид манай эрхэм хүндэт Сергог огтчиж сийчихийг зөвшөөрөхгүй.

Эмч, сувилагч нар явлаа.

Улс төрийн Товчооны гишүүд Оржоникизегийн хэвтэж байгаа орыг тойрч, талийгаачийн нүүр рүү харцгаав. Ганц Микоян л зайдуу хана налаад зогсож байна.

-Зина, ажлын өрөө рүү оръё гэж Сталин хэлэв.

Тэр өрөөний цонхоор Александрын цэцэрлэг харагддаг ажээ.

Сталин ороод хаалгыг сайн хаалаа.

-Чи утсаар юу донгосоод байв аа?

-Би донгосоогүй, чин үнэнийг хэлж байна, Иосиф, хэмээн Зинаида Гавриловна хоолой нь чичрэв. -Би дор байсан юм, Товчооны хурлын хар хавгас барьсан тусгай зарлага орж ирсэн... Би, “Николай яачихаав?” гэж асуусан. Байнга зарлагаар ирдэг Николайг асуусан маань тэр. Тэр нөхөр, “Николай өнөөдөр ажилдаа ирээгүй, ар гэртээ ажилтай” гэж хариулсан. Тэгээд хавгсаа барьсаар дээшээ гарсан...

-Хавгастай гэдгийг би ойлгож байна хэмээн Сталин түүний үгийг таслав. -Тэр чинь хавгас, бичиг цаас өгөх л гэж ирээ шүү дээ. Тэгээд яасан бэ?

-Дээшээ гарсан... Дараа нь бууж ирээд, “Зинаида Гавриловна, тэнд нэг буун дуу гарлаа...” гэж хэлсэн. Тэгээд яваад өгсөн. Би дээшээ гарсан чинь Григорий алуулчихсан байна.

-Алуулчихсан гэдэг чинь юу гэсэн үг вэ? Зарлага түүнийг алчихаа юу? Чи тэгж хэлэх гээ юү?

-Үгүй, үгүй... Би тэгж нотлож байгаа юм биш, яаж болохов, гэхдээ нэг л хачин...

-Чи буун дуу сонссон уу?

-Би сонсоогүй.

-Хэрвээ зарлага түүнийг алсан бол юу ч хэлэлгүй, зүгээр л яваад өгөх ёстой. Буун дуу сонслоо гэж яах гэж чамд хэлэх вэ? Чамайг дээшээ гүйж очоод, тусламж үзүүлэг, эмч дуудаг, түүнийг авраг, тэгээд дараа нь нөхөр Оржоникизе чухам энэ хүн алан хядах үйлдэл хийх гэж оролдсон, энүүнийг буудан алах хэрэгтэй гэж мэдүүлэг гэсэндээ тэр үү?! Тийм үү? Тэр чамд яах гэж буун дуу сонслоо гэж хэлэв? Надад тайлбарлаад аль. Тайлбар алга. Ер нь ч тэр яаж алж чадах юм бэ? Инээдтэй тэнэг зүйл. Би чиний байдлыг ойлгож байна, гэхдээ мунаглаж болохгүй.

-Гэхдээ, Иосиф хэмээн Зинаида Гавриловна эхлэв. -Би яг тэгсэн гэж зүтгээгүй, мэдээж, тийм байх ёсгүй, тэгсэн хэрнээ л...

-“Тэгсэн хэрнээ л” гэж хэрэггүй. Чиний санаанаасаа зохиосон элдэв юм, тэнэг таамнал хов живний үндэс болж мэднэ, намд хортой хов живний үндэс шүү. Чи үүнийг үнэхээр ойлгохгүй байна гэж үү? Биеэ барь! Гүтгэлгийн чанартай цуу тараавал нам чамтай хатуу ярина шүү. Зина, намын тэвчээрийг бүү шалга. Серго амиа хорлосон байна, гэхдээ түүнийг амиа хорлогч гэж гутаахыг нам хүсэхгүй байна. Нам түүний ариун нэрийг тэр чигээр нь хадгалж үлдэхийг хүсч байна. Тийм учраас бусад бүх хүний хувьд бол Серго ажлаа хийж байгаад зүрх нь дэлбэрч нас барсан болно. Энэ бол нам, засгийн онош. Чи намын гишүүн, чи үүнийг дэмжих үүрэгтэй. Харин одоо талийгаач руу оч. Климиийг наашаа ир гэж хэл.

Зинаида Гавриловна гарч хаалгаа хаамагц сая нулимс унагав.

Сталин бичгийн ширээ рүү очлоо. Өнгө өнгийн харандаагаар тэмдэглэл хийсэн том дэвтрүүд нээлттэй хэвтэж байна. Сталин тэдгээрийн хуудсыг эргүүлж үзэв. Өө, энэ байна, Бүгд хуралд тавих илтгэл. Яг түүний бичиг.

Ворошилов орж ирэв.

Сталин тэмдэглэлийн дэвтрүүд рүү зааж,

-Энэ Сергогийн илтгэлийн сэдэв. Энүүнийг бас ширээний нүдэнд байгаа бусад бүх бичиг цаасыг Поскребышевт шилжүүлэх шийдвэр өг гэж хэлэв.

Саша Тайшетэд хоёр долоо хоног саатсаны эцэст тэндээс арайхийж явав.

Вагоны дээд, доод вандан дээр хүмүүс бөөр бөөрөөрөө чихэлдэн сууцгаажээ. Хамгийн дээд талын ачааны тавиурыг эзлэж амжсан нэг нь хэвтгээд өгч. Дээшээ тулчихаад суух аргагүйн эрхээр тэр. Вагоны гудаагаар шалан дээр тавилсан ачаа тээшийг үйлчлэгч явах арга алга хэмээн шаардаж авахуулна. Зорчигчид чемодан, ууттай юмаа өвдөг дээрээ тавьж, цүхнээ тэвэрсэнээ үйлчлэгчийг өнгөрөнгүүт буцаагаад шалан дээр овоолчихно.

Хүүхэд шуухад уйлалдан, томчуул нь хараал зүхэл тавьж, бүгд уур уцаартай, бие биендээ царай өгөх шинж алга. Вагоноор нэг тамхины утаа. Галлахгүй байгаа учраас хүйтэн гэж жигтэйхэн, вагоны цонх бөөн цан хяруу. Зорчигчид бүгд гадуур хувцастайгаа сууцгаана. Үйлчлэгчид юу гэж ч гомдол мэдүүлээд нэмэргүй, Тэрээр,

-Красноярскт очоод л галлана даа гэж ам таглана.

Нэг жорлон нь түгжээтэй, нөгөөдөхөд нь бүгдээрээ оочерлоно. Дэмий л дараачийн өртөөн дээр зогстол тэснэ. Гэтэл өртөөн дээр очингуут галт тэргэнд суух гэсэн бөөн амьтан үг зүггүй шаваад дайрчихна. Үйлчлэгч суудал байхгүй гээд ганц ч хүн оруулахгүй. Тэр олон улсын дундуур зүтгэлж гарна гэж горьдсоны гарз, гарч гэмээ нь буцаад орно гэсэн ном байхгүй.

Тийм учраас Красноярск хүртэл тэвчээд суухаас өөр арга алга.

Саша орон нутгийн суудлаар Красноярскт очиж, дараа нь Новосибирскээр дамжин Свердловск хүрэв.

Красноярскаас ээждээ, “Замд явж байна, утасдана” гэсэн цахилгаан илгээв. Удаан бодсоны эцэст чухамхүү ингэж бичихээр шийджээ. түүний суллагдсан, тэгээд суурьших газраа очоод утасдах юм байна гэдгийг ээж нь ойлгоно. мань хүн Москвад аж төрж болохгүйг ээж нь гарцаагүй мэдэж байгаа, үүнийг бүгд мэдэж байгаа юм чинь.

Одоо хаачдаг хэрэг вэ? Хамгийн ойрхон нь Марк. түүний удирдаж байгаа завод мужийн төвөөс зайдуу, тэнд цөлөгдсөн нударганчууд, ялтан хэрэгтэн явсан улсаас авахуулаад есөн шидийн амьтад ажиллаж байгаа болохоор паспортын тусгай дэглэм тэднийд хамаарахгүй нь лав. Марк тэндээ эрх дархтай хүн юм чинь мань хүнийг аль нэг газар оруулж, байнгын паспорт авахад дэм үзүүлж чадна. Тэр хоёрын овог өөр учраас түүнд хал бал болохгүй.

Гэвч Саша энэ хувилбараа шууд үгүйсгэв. Улс орон даяар, бүх түвшинд, дээр доргүй юу гээч болж байгааг өөрөө үзэж байна, галд өртөөгүй, овоо хараанд онилуулаагүй хүн нэг ч алга, Марк ч онилуулчихсан байгаа. түүнд төвөг удах хэрэггүй.

Эцэг рүүгээ очих уу? Ефремов бас тусгай дэглэмгүй хот, юмны байр байдлыг мэдэж, зүг чигээ олтлоо хэсэг зуур хоног төөрүүлж болно. Гэтэл эцгийгээ бодонгуут баахан нажидтай дурсамж толгойд уралдаад орж ирэх нь тэр. Сав л хийвэл уцаарладаг, сэтгэлд нь таарах юм

гэж нэг ч байхгүй, нямбай нь дэндсэн эцэгтэйгээ нэг дээвэр дор олон хононо гэж худлаа. түүнээс гадна эцэг нь бас өөр гэр бүлтэй болсон биз. Амьтанд дараа болоод яхав.

Тэрээр Москвад үзэгдэх ёсгүй. Тэглээ ч гэсэн ээжтэйгээ золгож, Варятай мэнд мэдэлцэхийн тулд Москвагаар ганц өдөр ч хамаагүй, хэдхэн цаг ч яхав, дайраад гарах хэрэгтэй. Хэрвээ одоо дайрахгүй юм бол тэр хоёртой хэзээ, хаана уулзах юм бэ?

Азаа үзэх хэрэгтэй. Вера эгчийндээ очиж болно, ээж нь Варятай тийшээ хүрээд ирнэ биз. Галт тэрэгний буудал дээрээс эгч рүүгээ утасдана. Зөвшөөрөх эсэх нь дууных нь өнгөөр мэдэгдэнэ.

Эрсдэлтэй, аюултай алхам. Гэвч өөр зам алга.

Свердловскт Сашагийн аз таарчээ. Тасалбар, мэдээж, яаж байхав. Саша түгээврийн цонхны тэнд зогсож байтал цонх гэнэтхэн онгойж. мань хүн хамгийн түрүүнд ухасхийж очоод, цонх руу шагайн,

-Москва хүртэл ганц суудал байхгүй биз? гэж асуужээ. Тасалбарын хүүхэн мөнгөний тоо хэлэв. Саша хэлсэн мөнгийг төлж, тасалбараа аваад галт тэрэг рүү хар хурдаараа харайлгав. Цонх ч тэр дороо хаагджээ. Тусгай захиалгатай суудлаас цорын ганц үлдсэн байсан бололтой.

Задгай суудлын вагонд зорчигч бүр оногдсон байртай, Сашад дээд талын вандан таарчээ. Замын турш хэвтээд явсан ч болно.

Саша дугаартай суудлаа хайсаар нэг задгай тасалгаа руу шагайвал хүдэр гэхээр зурван залуу тухлан сууцгааж байж. Өмсгөл, мөрдэс энэ тэрийг харвал ДЯАК-ын харъяа цэргийнхэн гэдэг нь тодорхой.

-Залуу, чи яах гээв? гэж нэг ахлагч сүржин дүр эсгэв.

-Суудлаа харж байна.

-Чиний суудал хэд юм бэ?

-Арван зургаа.

Сайхь ахлагч дэслэгч рүүгээ харав. Вандангийн аравч налан сууж буй дэслэгч толгой үл мэдэг дохих шиг болсон нь ахлагчаа сайшааж байгаа юм санж. Цаадах нь улам сүржин дүрийг олов.

-Тасалбараа үзүүл!

Тасалбар дээр арван зургаагийн тоо байгааг үзээд, цааш хэрхэхээ үл мэдэх ахлагч тасалбарыг дэслэгчдээ өгөв.

-Энэ тасалбарыг хаанаас авсан юм?

-Түгээврээс.

-Үйлчлэгчийг дууд.

Дэслэгчийн үүргийг ахлагч хажуудаа сууж буй цэрэгт дамжуулав. Зиндаагаа барьж буй нь тэр.

Тэр цэрэг үйлчлэгчийг дуудахаар явлаа.

Энэ олон суудалтай вагонд очиж очиж ийм юмнуудтай таарах гэж! Бүүр нэг шижээргүй царайлж, хүйтэн нүдлээд байж байгаагүй нь. За, энэ муусайн яадаг юм бэ! Саша дээд талын вандан дээр чемоданаа хаяв.

Үйлчлэгч ирлээ.

Дэслэгч Сашагийн тасалбарыг түүн рүү сарвайж,

-Энэ юу юм бэ? гэв.

-Та өөрөө харахгүй байна уу? Тасалбар л байна. Наймдугаар вагон, арван зургадугаар суудал. Бүх юм ёсоороо байна.

-Энэ суудал дээр бид Казаниас хүн авах ёстой гэж дэслэгч дүрэмдэв.

-Казаньд очтол учир нь олдоно биз.

-Бид энэ дөрвөн суудлыг тусгайлж захиалсан гэж дэслэгч зөрөв.

-Хаа байна, тэр захиалга чинь? Захиалга түгээвэрт хамаатай болохоос надад падгүй, надад бол тасалбар л зарлиг, энэ зөв тасалбар байна, иргэн гуай, суудлаа эзлээрэй гээд үйлчлэгч Сашагийн тасалбарыг буцааж өгөв.

Тэгээд яваад өгөв. Иймэрхүү хянагчдын дээрэлхүү занд дасчихсан бололтой. Эд нарыг хянагчид гэдэгт эргэлзэх юм алга. хэн нэгнийг хүргэж өгчихөөд, буцахдаа гаднын хүнгүй амьхнаараа явцгаах гэж л дээ.

Саша чемоданаа вандангийн мухар руу, цонхны тэр рүү түлхэж, эсгий гутлаа наанаас нь дэрний оронд тавиад пальтогоо нөмрөөд хэвлээ. Тэгсхийгээд нам унтжээ.

Галт тэрэг огцом тооромсоглох шиг болж Саша сэрэв. Нөгөөдүүл нь унтацгааж байна. Дэслэгч Сашагийн эсрэг талд дээд талын вандан дээр, ахлагч, цэрэг хоёр доод вандан дээр. Уул нь хэн нэг нь жижүүрлэж байх ёстой биш үү. Гар буугаа дэрэн дороо хийцгээчихээд хурхирч байгаа юм байлгүй.

Галт тэрэг зам төмрийн уулзуур дээр нэгэн хэмээр түгчүүлэн давхиж явна.

Цөллөг дууссан, цөллөгнөөс буцаж яваа, з а м д я в а а г а а Саша анх удаагаа тодхон

мэдэрлээ.

Саша нөгөөдүүлийг сэрээхээс болгоомжлон, гутлаа чимээгүй углаж сэмээрхэн бууж жорлонд ороод, буцаж орон дээрээ сэвхийн гарч, дахиад унтаад өгөв.

түүнийг дахиад сэрэхэд цонхоор өвлийн өглөөний бүдэг гэгээ сүүмэлзэж байв. Цагаа харлаа. Ес! Галт тэрэг нэг өртөөн дээр зогсож байна. Цонх хөлөрчихөөд өртөөний нэрийг бас харж чадсангүй. Зорчигчид хэдийн босчихсон, вагоны хаалга байн байн онголзож, сав л хийвэл агаарын хүйтэн урсгал орж ирээд байв. Вагоны ус буцалгагч ажилгүй, хүмүүс данхаараа өртөөн дээрээс буцалсан ус авчирцгааж буй нь тэр юм байж. Сашад нөгөө Тайшетэд худалдаж авсан сэнжтэй аяганаас өөр сав байхгүй, тэр аягаар яаж гаднаас ус авчрах вэ дээ.

Тэрээр хэвтгээгээрээ пальтоныхоо халааснаас Свердловскт авсан сониноо гаргаж ирэв. Тэдгээрт Пятаков-Радекийн хэргийг шүүн таслах ажиллагааны тухай, троцкийч тагнуулчдын хорон санаат арга явуулгын тухай зөндөөн юм бичжээ.

Хянагчид өглөөний ундаа ууцгааж байна. Нөгөө ахлагч чанасан өндгөө ширээ рүү тогшлон хагалж, хальсыг нь шууд шалан дээр хаялав.

-Аль вэ, би гаргаад хаячихья гэж цэрэг өгүүлэв.

-Яахийм, үйлчлэгч шүүрдэнэ биз, түүнд өөр хийх юм байх биш.

Дэслэгч ахлагчид нэг юм хэлэв. Чухам юу гэж хэлснийг Саша ялгаж сонссонгүй.

-Хөөе, хөрш өө, бууж цай уу гэж ахлагч дуудав.

-Баярлалаа, ус буцлахыг хүлээнэ ээ.

-Дэндүү удаан хүлээх хэрэг болно, буугаад ир. Бид нар идэж уучихаад, унтах гээд хэвтгээд өгнө шүү. Тэгвэл чи хаа сууж гудрах юм бэ? гэж дэслэгч дээшээ харах ч үгүй өгүүлэв.

Саша уутаа задлаж, сэнжтэй аяга, талх, ганц сонгино, сүүлчийн хоёр ширхэг ёотон, эцсийн хэрчим жирээгээ гаргав. Шал нь нойтон бохир учир чемоданаас савхин гутлаа гаргаж өмсөөд доошоо буув.

Ширээн дээр данхнаас гадна зузаан зузаан хэрчсэн талх, бас том томоор нь зүссэн чанамал хиам, хальсалсан өндөг, аягатай цөцгийн тос энэ тэр байна. Дэслэгч, ахлагч хоёр ширээг хоёр талаас нь эзэгнэн суужээ. Харахад дүйнгэдүү болов уу гэмээр, гэхдээ үйлчлэгчийн хөдөлмөрийг үнэлснийг бодоход цаадуулаасаа эрхбиш нүнжигтэй биз, шалхгар царайтай цэрэг хажууханд нь суумаглаад, чимээгүй бувар бувар зажилж байна. Саша түүний өөдөөс сууж, ширээний өнцөг дээр аяганы хийцээ тавив. Дэслэгч, ахлагч хоёр хүнсийг нь нэгэнтээ тоомжиргүй харав.

Дараа нь дэслэгч үлдсэн архиа гурван биендээ хувааж аягалав.

Архиа ууцгааж, хиамаар даруулцгаалаа.

Саша сонгиноосоо нэг дэлбээ холтолож талхтайгаа хольж идэв.

Ахлагч буцалсан уснаас аягалахдаа Сашагийн аяганд бас хийв.

Дэслэгч сэнжтэй аягаа хоёр алгандаа барьж гараа бүлээцүүлэнгээ нэгэнтээ балгав. Тэгснээ,

-Хаанаас явж байна даа? гэж Сашагаас асуув.

-Подкаменная Тунгускаас.

-Гол уу, юу вэ?

-Гол. Красноярскийн хязгаарт, Эвенкийн үндэсний тойрогт байдаг юм.

Дэслэгч эдгээр нэр усыг сонсож яваагүй ч, юм мэдэхгүйгээ нуух санаатай до яамныхны дадал болсон үл итгэгчийн дүрийг эсгэв.

-Ажил хийгээ юү?

-Тийм. Профессор Куликийн шинжилгээний ангид. Тунгусын солирыг хайж байгаа юм. Дуулаагүй юү?

-Дуулсаан. Тэнгэрээс унаа биз дээ.

Саша сэгхийх шиг болж санаа алдав. Ярих юм нь тэдэнд одоо үнэмшилтэй байх болно. Тунгусын солирын тухай хориод оны сүүлч, гучаад оны эхээр сонин хэвлэлээр бөөн шуугиан дэгдсэн бөгөөд одоо бичихээ нэгэнт больсон учир боловсрол нимгэн энэ дэслэгч тэр тухай сонссон буй нь том аз. Эд нар чинь яаж ч мэдэх улс, өөрсдийнхөө ойлгохгүй ганц үгнээс зуурч аваад, юу гэж ч мугуйдалж чадна. Саша Тунгусын солирын тухай хөндсөнөөр цаашид ярилцах аюулгүй сэдэвтэй болох нь энэ.

-Тэр солир гучаад жилийн өмнө, 1908 оны зургадугаар сарын 30-ны өглөөний долоон цагт унасан юм. Ер нь солир гэдэг бол тэнгэрийн эрхэсийн хэлтэрхийнүүд, гариг хоорондын огторгуйгаас газар дээр унадаг юм, дэлхийн агаарын давхрага руу орохоороо шатчихна. Том нь их хурц гэрэл гаргаж шатна, тиймийг нь болид гэдэг юм, жижгүүд нь бол бидний од харвалаа гээд байдаг чинь шүү дээ.

-Тэрийг чинь ч харахаараа нэг болсон шүү гэж ахлагч өгүүлэв.

-Тунгусын солир бол, мэдээж, аврага том болид байсан хэмээн Саша түүн рүү харав, -Хоёр мянга орчим квадрат километр талбайг сүйтгэсэн гэж үздэг юм.

-О-хоон! гэж уулгалан ахлагч хэхрэв.

-Тэр болид тэнгэрээс харваж яваа нь Зүүн Сибирийн бараг бүх нутгаас харагдсан гэж байгаа. Тэгээд унахдаа чих дөжрөм дэлбэрэлт болсныг хэдэн мянган километрийн цаана сонссон гэдэг юм. Олон тосгон сууринд орон байшин чичирч, цонхны шил хагарч, тавиураас сав

суулга нурж, тэр ч атугай, хүн, мал хөл дээрээ тогтохгүй унаж байсан гэж байгаа. Яг л газар хөдлөлт гэсэн үг. Англид хүртэл бүртгэгдсэн байдаг юм.

-Английн тухай чи яаж мэдэв? хэмээн дэслэгч хирдхийлээ.

-Хувьсгалын өмнөх сонинуудад тэгж бичсэн байдаг юм. Солир хувьсгалаас есөн жилийн өмнө унасан юм.

Дэслэгч энэ тайлбарт ханав бололтой.

-Тэр солир чинь, өөрөө тэгээд хаачсан юм бэ?

-Шатчихсан. Дэлхийн агаарын давхрага руу оронгуутаа хуу шатаад тоос болж хувирсан.

-Юунаас болж шатах нь тэр вэ? гэж дэслэгч дахин хирдхийв.

-Үгүй, яахав, тэр чинь асар их хурдтай унадаг юм. Секундэд арван хоёр километр, буюу цагт дөчин мянган километрээс илүү хурдтай. Жишээлбэл, бидний галт тэрэг их л сайндаа, цагт тавь, жаран километр явна, гэтэл тэр болид бол дөчин мянга, тэгэхээр ямар их үрэлт гарах вэ! Чухамхүү үүнээс болж асар их халуун- арван мянган хэмийн халуун үүсч, тэр болид шатаж зөвхөн тоос үлдэнэ. Тэр тоос нь эрчээрээ газрын гүн рүү орж, ормон дээр нь нуур, намаг тогтсон юм.

-Тэгвэл юугаа хайдаг юм бэ?

-Юуны чинь юугаа гэж? Солирын үлдэгдэл хайхгүй юү.

-Чи, залуу, жаахан залаад байна шүү! Эхлээд тоос гэж ярьсан, одоо болохоор солирын үлдэгдэл болчихлоо. Тэр үлдэгдлээр чинь яадаг юм бэ?

-Солир, тэнгэрийн бусад эрхэс юунаас бүтдэгийг түүгээр тодорхойлохгүй юү.

-Шинжлэх ухааны тулд тэгэх нь хэмээн дэслэгч тамшаалав.

-Чухам тэр чинь, шинжлэх ухааны тулд.

-Тэгвэл, бидэнд тийм шинжлэх ухаан хэрэгтэй юм уу?

-Юу гэсэн үг вэ? гэж Саша эс ойлгож асуув.

-Юусах юу байхав. Социалист байгуулалтад тийм шинжлэх ухаан хэрэгтэй юү, элдэв чулуу хайдаг, тийм шинжлэх ухаан хэрэгтэй юү?

-Солирын хэлтэрхий хайх шийдвэр з а с г и й н г а з а р гаргасан, тэгэхээр хэрэгтэй л байх нь дээ гэж Саша нухацтай өчив.

Засгийн газар гэж хэлэнгүүт дэслэгч хоолойгоо ихэмсгээр шахаж,

-Тэгээд яав, олов уу? гэж шаардах маягтай асуув.

-Үгүй, хамаг юм газар дор ороод шороотой холилчихож. Бас тэндхийн нөхцөл их хэцүү, зам харгуй байхгүй, жинхэнэ нарийн тоног төхөөрөмж тийш нь аваачих аргагүй, ер нь хүнд бэрх ажил, ялаа шумуулыг нь яана, ажиллая гэх хүн олдохгүй шүү дээ.

-Яагаад олдохгүй гэж? Засгийн газрын даалгавар байгаа юм бол ажиллах л ёстой гээд дэслэгч хөмсөг зангидав.

-Хүмүүсийг зөвхөн улирлын чанартай, зунд нь хөлсөлж аваад, өвөлд нь халчихна. Тэгэхээр дахиж хөлслөгдөх дургүй, шумуулын хоол болохыг хүсдэггүй юм гэж Саша тайлбарлав.

-Хоригдол явуулахгүй юү, тэд татгалзана гэх биш гэж ахлагч хөндлөнгөөс өгүүлэв.

-Жижигхэн объект биз, хэдэн хүн ажиллахаав? гэж дэслэгч мэдэмхийрэв.

-Улиралдаа хорь, гучин хүн.

-Цөөхөн юм аа хэмээн дэслэгч бодлогошров.

-Томилолтоор явуулж болно, нэг амбаар барьчихгүй юү, тэгвэл өвөл ч гэсэн ухна, үхэхгүй нь лав хэмээн ахлагч санал болгов.

-За тэр яахав, бидэнтэй бидэнгүй учраа олно хэмээн дэслэгч ахлагчийнхаа амыг таглав. - Ингэхэд нэр чинь хэн бэ?

-Саша.

-Чи өчигдөрийн яасанд битгий гомдоорой. Харж байгаа биз дээ, бид зэр зэвсэгтэйгээ албан үүргээ гүйцэтгэж явна, бичиг баримт авч яваа учраас хэнтэй явж байгаагаа заавал мэдэж байх ёстой. Ойлгов уу?

-Ойлголгүй яахав.

-Сонор сэрэмж шүү дээ гэж ахлагч тайлбарлав.

-Чи бодвол сонин уншдаг байлгүй гэж дэслэгч өгүүлэв. -Энэ, нөгөө шүүх ажиллагааг мэднэ биз дээ... Юу болж байгааг харж байна уу? Эргэн тойрон тагнуул, хорлон сүйтгэгчид, бүр хамгийн орой руу нь хүртэл мацаад гарчихаж, тийшээ нэвтэрчихэж.

-Тэр муусайн хорт могойнуудыг буйраар нь үнсэн товрог болгох хэрэгтэй гэж ахлагч сэжиглэн ярвайв. -Тэр муусайн дайснуудыг, тэднүүсийн авгай нарыг, тэднүүсийн гэр бүлийг толгой дараалан хүйс тэмтрэх хэрэгтэй.

-Хүүхдийг яасан гэж тэр вэ? хэмээн Саша инээвхийлэв.

Дэслэгч түүн рүү сэжигтэй харав.

-Тэднүүсийн хүүхдийг өрөвдөө юү?

-Хүүхдийг хүмүүжүүлээд авч болно гэж бодож байна.

-Тэр хүүхдүүд том болохоороо чи бид хоёрыг заяа нь өрөвдөхгүй хэмээн дэслэгч нүдээ онийлгов. -Аванцар, ээжинцэрийнхээ өсийг биднээс авна. Тэдний өрөвдөлт гэж юу байхыг тэр үед мэдэх болно.

Ахлагч хажуунаас хошуу нэмэв.

-Тэд нарыг хүмүүжүүлэх гээд үзээрэй, ёсонд хазгай. Би амралтаараа тосгондоо очлоо, Вологда муж руугаа. Тэгсэн чинь манай хамтралын дарга хорлон сүйтгэгч болж таарч. Нягтлан бодогч, бригадын дарга хоёр бас хорлон сүйтгэгчид, троцкийчууд юм байж. Мэдээж, тэд нарыг шоронд хийчихэж. Бригадын даргын хүүхнийг дуудаж авчирч. мань хүүхэн, би яасан юм бэ, би олон нялх нойтон хүүхэдтэй хүн гэж гаслаж гинаж, орилж чарласан гэж байгаа... Уул нь нас яагаа ч үгүй, аюулын бие хаатай, дажгүй хүүхэн. Мөрдөн байцаагч түүнд, “Чи яагаад ардын дайсны үзэл бодлыг нуусан юм бэ?” гэж. -“Ямар дайсны?” -“Хар хүн шүү юмныхаа, Арсентий Назаровын”. “Би түүнийг дайсан гэж мэдээгүй”. Гэтэл мөрдөгч түүнд, “Чи чинь хэнтэй унтаж байгаагаа харахгүй байсан юм уу?” гэж. Асуултыг тэгж тавьсан гэж байгаа. Найман жил хүртээсэн гэнэ лээ, одоо хэнтэй унтахаа мэддэг болж таарна, хүүхдүүдийг нь асрамжийн газар явуулчихсан.

-Харав уу, хүүхдүүдэд нь санаа тавьсан байна... гээд дэслэгч Саша руу харав. Бүх юм нь бэлэн зэлэн асрах газар руу явуулж. Гэтэл чи тэднийг өрөвдөөд байсан. Чи өөрөө хүүхэдтэй юү дээ?

-Бий гэж Саша худал өчив.

-Тэгээд л өрөвдөж байх нь. Харин дайсан биднийг өрөвдөж байна уу? Нэг нөхөр рүү, хүн шиг санаад очиж л дээ, том албатайг яана, районы гүйцэтгэх захиргааны дарга, яг хуулийн дагуу, баривчлах, нэгжлэг хийх зөвшөөрлийн бичигтэй очихгүй юү. Тэгсэн чинь тэр этгээд гар буугаа шүүрч буудалцаж эхэлсэн гэж байгаа. Манай хоёр хүнийг газар дээр нь нухчихаад, сүүлчийнхээ сумыг өөртөө зоочихсон, ёстой хүний адаг, муу урвагч, тагнуул. Өргөсөн тангаргийнхаа ёсоор албан үүргээ гүйцэтгэж яваад амь эрсэдсэн манай хоёр нөхрийг өрөвдөөгүй. Бас эхнэр, охин хоёроо ч өрөвдөөгүй. Эхнэрийг нь буудан алж, охин нь арван тавтай байсан учраас найман жилээр заагдсан. Өрөвч сэтгэл гэдэг ийм л гай болж хувирдаг байгаа юм.

-Нээрэн, ямар янзын юм болж байна аа... хэмээн Саша толгой сэгсрэв.

Тэрээр цайгаа гүйцээж ууж, талархал илэрхийлээд, вандан дээрээ гарч зүүрмэглэв. Тэгсхийгээд сэрснээ унтаж байгаа царайлан хэсэг хэвтэв. Дахиад зүүрмэглэснээ дахин сэрэв.

Нөгөө гурав нь хэсэг унтсанаа босч, үдийн хоол идсэн боловч мань хүнийг дуудсангүй, нэгэнт хэн болохыг мэдсэн хойно бол оо гээд сонирхохоо болио биз. Саша ч дотроо баяртай байж. Цаашаа хөрвөөж, унтаж байгаа дүртэй байсан чинь нэг мэдэхнээ үнэхээр унтаад өгч.

Бүр орой болсон хойно сэрэв. Галт тэрэг зогсчихсон, вагонд нэлээд хөл үймээнтэй байхыг бодвол том өртөөн дээр ирсэн бололтой. Нөгөө гурав алга, юм нь ч алга.

Дараа нь нэг хүүхэдтэй хоёр хүүхэн тэдний өрөө рүү орж ирэв. Араас нь нэг эрэгтэй хүн чемодан оруулав.

-Ямар өртөө вэ? гэж Саша асуув.

-Казань.

Тэгэхээр хянагчид худлаа залж ээ. Казань хүртэл амьханаараа явах гэж тэр. За, ямай, ямай! Өглөөний ярианаас болж сэтгэлд гуниг хуржээ. Өөрийгөө доромжилсон гэхээр юм огт яриагүй ч, тэр муусайн алуурчид, яргачид, нохойн гөлөгнүүдтэй зөрж чадаагүй. Мэдээж, тэд нартай яриа дэлгэж болохгүй, санаанд оромгүй ямар ч муухай юмаар төгсөж мэднэ, гэхдээ тэдэн рүү бууж очиж, хамт суух хэрэггүй байсан юм. Та нар өчигдөр намайг оруулахгүй байсан, та нартай мэдэлцэхийг хүсэхгүй байна гэж болох. Эсвэл “Салхи авчихсан байх, хамаг бие хөрзийгөөд” гээд өвдсөн хүн болж, тэднээс буцалсан ус гуйж аваад, вандан дээрээ юмаа идчихгүй юу. Гэтэл мань хүн тэдэн рүү бууж очиж нийлсэн. Өөрийг нь хардахаас сэрэмжлэх гэсэндээ профессор Куликийн шинжилгээний анги, Тунгусын солир энэ тэр гэж худлаа ярьсан, уул нь санаснаар болж, түүнийг цөллөгнөөс буцаж яваа гэж тэдний толгойд өчүүхэн ч хар буугаагүй.

Одоо байнга ингэж худлаа ярьж аж төрөх нь. Өнгөрснөө бүдгэрүүлж далдлахын тулд, элдвээр хоргоолгож шалгаалгахгүйн тулд уулзсан, зөрсөн бүхэнд худлаа юм зохион ярьж, булзаж булгаж явах нь. Ээ, мөн хэцүү еэ. Гэвч өөр гарц алга. Өөрийгөө цагаатгуулах, хэргээ дахин хянуулах гэсэн аливаа оролдлого шинэ ялын хугацаа авахын цондон болно. Одоо бол цөллөгт явуулах биш хориход хийнэ, гурван жил биш тав юм уу, бүр найман жил наачихна. Хэрвээ болгоомжтой байхыг хүсэхгүй бол, ял эдлэж явснаа нуухгүй бол шоронгийн хаалга бүр ч түргэн татна.

Саяны дэслэгч, ахлагч хоёр, жишээлбэл, мань хүнийг торны цаад руу яасан бахтай хийж байх бол. Шоронгоор дамжсан аливаа хүн тэдний хувьд г о м д с о н хүн, тэгэхээр Зөвлөлт засагт муу санаж яваа хүн. Хэрвээ тэд нар золгүй бяцхан хүүхдүүдээс айж, “ааванцар, ээжинцэр”-ийнхээ өсийг авна гэж муу ёрлож байгаа юм бол, Саша шиг амьтдыг боомилж байхгүй хаачихав. Ингээд л хөмөрсөн тогооны үлгэр болчихоод байгаа юм: мань хүн т э д н э э с айхын эрхэнд худлаа хэлж, нуугдаж явахаас өөр аргагүй, гэтэл ц а а д у у л нь г о м д о г с о д о о с айхын эрхэнд тэднийг шорон руу чихээд байдаг. Тэгэхээр энэ ёс хэзээ ч өөрчлөгдөхгүй. Тэгэхээр мань хүний байдал хэзээ ч өөрчлөгдөхгүй. Тэгвэл түүний айдас бас хэзээ ч арилахгүй гэсэн үг.

За яахав! Өө, юм идмээр байгаа юм байна шүү дээ. Одоо эндээс бууж, үйлчлэгчийг олоод буцалсан ус шаардана. Тасалбарын үнэ төлсөн үү? Төлсөн. Тэгвэл вагоныхоо зорчигчдыг буцалсан усаар хангаж хайрла! За, за, чөтгөр авмар, түүнтэй толхилцоно гэхээс залхуу хүрч байна, талхаа хуурай гоочлох минь.

Ер нь бүтэх, бүтэхгүйн санааг орхих хэрэгтэй. Ард нь цөллөг үлдлээ, өмнө нь хорих лагерь

байна, энэ бол тодоос тод зүйл, харин одоо бол түр амралттай байгаа хэрэг. Яг түр амралт. Харин эрх чөлөөтэй хичнээн өдөр хоног заяахыг хэн ч хэлж чадахгүй. Аз л мэднэ дээ.

Өглөөний ундан дээр Феня цай өгөх гэж байгаад аягатай цайгаа Вадимын өвдгөн дээр алдчихав.

Вадим босон харайж, халаадаа сэгсэрлээ.

-Хаашаа тавьж байгаагаа хардаггүй юм уу, заяагүй дүйрэн!

-Үнэхээр юу ч харахгүй байна, Вадимушка минь, нулимсандаа болоод нүд бүр ширгэж гүйцлээ.

Тэгснээ яг хөдөөний авгай шиг үглэж дуулж гарлаа:

-Ээ бурхан, ээ бурхан минь, яасан гэж ингэж залхаана вэ? Тэр муу өвгөн хэнд саад болоов? Ялаа ч гомдоохгүй номхон амьтан. Ач, зээ нь насанд хүрчихсэн өтөл хүн шүү дээ, яасан гэж тэр вэ? хэнийг ч хөнддөггүй, хэнийг ч удирддаггүй хүн, үсчний газрын эрхлэгч бол гэхэд нь, “Үгүй ээ, хэрэггүй, нүглээс холхон явах минь” гэж дургүйлхээд татгалзсан... Тэгсэн чинь одоо шоронд орчихож. Настя, авгай нь тийшээ очсон, Бутыркийн шоронд...

-Юун Настя, юун үсчин, юун Бутырка вэ?! хэмээн Вадим түүнийг зандрах зуур, Феня одоо Сергей Алексеевичийн нэрийг хэлнэ гэхээс дотор нь харанхуйлах шиг болов.

-Яагаав Настя, Сергей Алексеевичийн авгай... Манай Сергей Алексеевич Бутыркийн шоронд сууж байгаа гэснээ Феня дахиад гаслаад эхлэв. -Настя зөндөөн явсан, юм оруулдаггүй гэнэ, мөнгө ч хүлээж авдаггүй гэнэ, одоо мөрдөнд байгаа учраас тэр юм байх... Гэтэл юун мөрдөн бэ? Яаж үс засч, яаж сахал хусч байсан гэж мөрдөж байгаа юм уу?.. Нэг муу гайтай хөөтэй амьтан л түүнийг гүжирдсэн, тэр муу хараал идмэрийг чөтгөр шулам тасдаж хаяасай, өвчний муу тусч, хумхаа чичрэгээр хатингарлаж үхээсэй, өөрөө ч үхэж хатаг, үр хүүхэд, ач зээ нь үхэж хатвал таарна...

-Больж үз, болиоч! Нулимс тус болохгүй, больж үз! гэж Вадим толгой сэгсрэн өгүүлэв. Энэ ёрын муухай мэдээ түүний сэтгэл санааг уймруулж, ингээд ажлын нэг өдөр тэр чигээрээ өнгөрөх нь энэ.

-Вадимушка минь, чи тусал л даа, чи сонинд юм бичдэг нэр цуутай хүн, бас Андрей Андреевич бүх дарга нарыг эмчилдэг хүн. Хөөцөлдөж үзээч! Та нарын үгэнд орохгүй гэж байх уу даа?!

Ийм хэрэгт хэн ч хэний ч үгэнд ордоггүй, хэн ч хэнд ч тусалдаггүйг яаж энэ хөдөөний тэнэг авгайд ойлгуулах вэ дээ.

-Юу хийж болохыг би бодъё. Гагцхүү үглэж дуулахаа больж үз гэж Вадим хэлэв.

Феня чимээгүй болж, ширээн дээрхээ хураалгүй, гал зуухны тэндэх өрөө рүүгээ яваад өгөв. Вадим өөрийнхөө өрөө рүү сажлаж очоод орон дээрээ ойчоод өгөв.

Вадим Сергей Алексеевичид онигоо ярьсан тухайгаа Альтманд мэдүүлж, протоколд гарын үсэг зурснаас хойш түүгээр үсээ засуулахаа больжээ. Калошины гудман дахь үсчингийн дэргэдүүр өнгөрөх бүрий түүнийг гомдолорхуу хачин сэрэл эзэмдэж, Сергей Алексеевич үзэгдэх вий гэхээс дургүй нь хүрнэ. Тэрээр хэлэх хэлэхгүй газар юу гэж нөгөө “Лев Давыдовичгүй бол болдоггүй ээ” гэдгийгээ хавчуулж, дэмий балай бурж байдаг байна аа? Тэгснийх нь төлөө мөрөөрөө хүмүүс нажидаа эдлэх ёстой юм уу? Ер нь ч заваан өвгөнөөр үсээ засуулах хэрэгцээгүй болсон. Вахтанговын театрт шинээр ирсэн нүүр будагч залуухан хөөрхөн хүүхэн үс сайхан засдаг тул Вадимыг танилууд нь түүнтэй уулзуулж өгчээ. Тэр хүүхэнд илүү хэд гурван мөнгө нь ч юу шиг байхав. Энэ бүсгүй ийшээ эртхэн ирэх нь яав аа, тэгсэн бол Вадим түүнд Радекийн тухай онигоог заяа нь ярихгүй байсан, тэгсэн бол Альтман өөрийг нь ингэж зовоохгүй, мань хүн ч хамтран ажиллана энэ тэр гэж ам өчиг өгөхгүй, Сергей Алексеевич ч үсчингийнхээ газар тэнгэрт хальтлаа ажиллахгүй юу.

Ээ, хөөрхий зайлуул... Лев Давыдовичийн тухай тэнэг сул үгнээс нь болж түүнийг үнэхээр баривчилж чадна гэж үү? Тэд нарт чадахгүй юм байхгүй. Гэхдээ яах гэж барив? Тэд нар одоо хичнээн ажилтай байна, сүр дуулиантай шүүн таслах хурлууд хийлгэж, том том арга хэмжээ хэрэгжүүлж байж, тэр муу өчүүхэн үсчнээр тэд яана бол доо?

Гэхдээ, нөгөө талаас, өвгөн Троцкийн тухай тэр үгээ, юу ч болсон бай, цөмийг нь Лев Давыдович руу чихчихнэ гэсэн шиг тохуурхсан маягтай хэлдэг байсан.

ДЯАК-д итгэх хэрэггүй, бүх гэмт хэрэгтний ард Троцкий байгаа гэдэгт итгэх хэрэггүй гэж үйлчлүүлэгч нартаа тийм байдлаар ятгалга хийж байж. түүний үйлчлүүлэгчдийн нэг нь нөгөө үгийг чухамхүү ингэж дүгнээд Лубянка руу хов хүргэсэн хэрэг. Харин Вадим өөрөө бол энд ямар ч холбогдолгүй. Альтман тэр хоёр үсчний тухай бараг жилийн өмнө ярьсан шүү дээ. Вадим тэгэхэд Эльсбейнийг ч нэрлэсэн, Ершиловыг ч нэрлэсэн. Тэр хоёр эрх чөлөөтэй, аж төрдөг янзаараа аж төрөөд л явж байна, харин Сергей Алексеевичийг барьчихаж. Тэгэхээр түүний тухай саяхан алтан хошуу өргөсөн байх нь, жилийн өмнө тиймэрхүү яриаг тоодоггүй байсан бол одоо энэ чинь эрүүгийн хэрэг. Учир зүйд таарч байна уу? Таарч байна.

Вадим цагаан цамц угаасан эсэхийг лавлах дүрээр Феня дээр очингоо, Сергей Алексеевичийг хэзээ барьсныг санаандгүй мэт асуув. Хоёр долоо хоногийн өмнө барьсан аж. Бүгд таарч байна! Энэ санааг зууран авч, түүндээ итгэж тайвшрахыг хүссэн боловч ер тайвширч чадсангүй. Өөрийнх нь мэдүүлэгт Сергей Алексеевичийн нэр байгаа, тэр мэдүүлэгтээ Вадим өөрийн гараар гарын үсэг зурсан, яах аргагүй өөрийнх нь хариуцах нүгэл. Уул нь өөрийгөө зөвгөх ганц юм бий: Вадим тэгэхэд үсчин өөрөө мэдээлэгч, тийм учраас түүнд ямар ч аюул нүүрлэхгүй гэж бодсон. мань хүн алдсан байх нь, Сергей Алексеевич шивэгчин биш байх нь, гэм халгүй хүнийг дэмий балласан байх нь.

Ямар муухай, аймаар юм бэ... Альтманаас учрыг тодруулна гэвэл санасны гарз. Вадим хоёр долоо хоног тутамд түүнтэй “Москва” зочид буудалд уулзаж, ээлжит товч мэдээгээ өгдөг билээ. Тэр нь социалист реализмын аргад үл нийцэх, тийм учраас зөвлөлт засагт дайсагнасан аль нэг бүтээлийн тухай товч шүүмж. Альтман ширээний ард сууж байгаад түүнийг уншина. Вадим буйдан дээр суугаад хүлээнэ. Мэдээж, Альтман зохиолчдын дотроос олон мэдээлэгчтэй байгаа, нөгөө Эльсбейнийг ч бодсон тэр, өөр ч зөндөөн хүн бий, Вадим үүнд өчүүхэн ч эс эргэлзэнэ, гэхдээ өөрийнх нь мэдээлэл нарийн мэргэжлийн түвшин, утга

зохиолын ур чадвараараа бусдаас гоц. Нэмэрт нь, мань хүний чих их урт, “дээгүүр” хэнийг сайшааж, хэнийг муушааж байгаа, хэнийг бутниргэх гэж байгаа, хэнийг бүр барьчихаад байгаа энэ тэрийг андахгүй. Гэхдээ хамгийн гол юм бол түүний совин, зөн совингоороо баргийн юмыг тээр урьдаас мэдэрч, юу “талхинд” орох, юу эс орохыг яг тодорхойлж чадна. Тийм учраас түүний мэдээлэл үйл явдлын араас биш, сонин хэвлэлээс түрүүлж ч гэх юм уу, өрсөх маягаар эзэндээ хүрнэ. Чухамхүү энэ “өрсөлт” л түүнийг аварч байгаа билээ.

Альтман шүдэнзээ хавирч тамхиа асаана. Вадимыг өөрийг нь зураад авах шиг санагдах энэ шүдэнзний хавираа Альтман юмаа уншиж дууссаныг илтгэнэ. Энэ мал ямар зан аяг гаргахыг урьдаас таахын аргагүй учраас Вадимын хувьд хамгийн зовлонт мөч эхлэж, Тэрээр айсандаа царай нь зэвхийрэн Альтман руу гөлөгнөн харна. Цаадах нь заримдаа “Хангалтгүй байна” хэмээн гүвтнээд бичсэн цаасыг нь сэжиглэх мэт хуруугаараа цааш нь түлхчихнэ. Вадим, өөр мэдээ сэлт байхгүй гэж өөрийгөө зөвтгөхийг оролдон арчаагүй царайлна. Альтман заримдаа “Баяртай” гэж товчхон хэлэх нь бий, тэгэнгүүт мань Вадим бушуухан далд орохын түүс болж, цахилгаан шат ч хүлээхгүй, таван давхрын шатаар харайлган уруудна.

Альтман нэг удаа Афиногеновын “Алслахуйн” тухай бичсэн шүүмжийг нь уншиж гүйцээд тамхиа асааснаа, сандал руу толгой дохиж,

-Наашаа суу, жаахан ярилцъя гэжээ.

Вадим ч ойртоод сууж.

-“Алслахуйн” Мальког Щукин уул нь сайн тоглосон шүү дээ, эсвэл та муу тоглосон гэж үзэж байна уу, энэ тухай танд өөр бодол байна уу?

Ээ, тэнгэр минь, бас Щукинтай холбох нь уу? түүнийг танихгүй, тийм алдартан чинь залуучуудыг өөртөө хавьтуулдаггүй юм гэж хэлнэ дээ. Гэтэл Щукинийг эцэг нь хэд хэдэн удаа үзсэн, зүгээр ч үгүй, эмнэлэгт бус гэртээ үзэж зөвлөлгөө өгснийг Альтман мэдчихсэн бол яана? Тэгвэл, “Марасевич, та бас л худлаа ярьж байна, туж худлаа ярьдаг” гээд хашгираад эхлэнэ. Яриаг Щукинаас Афиногенов руу шилжүүлэх ганц зам байна. Энэ бол дарагдахгүй хөзөр. Нэгд, Афиногеновыг одоо ид шүүсийг нь шахаж байгаа, мань хүн “Алслахуйн” тухай бусдыг давтахгүй бичих гэж яггүй зүдэрсэн. түүний шүүсийг шахдаг нь зөв: “Социалист реализмын” тухай Сталины томъёололтой зөрөх хэрэг юу байна? Явж явж үүнийг юу гэж ч нэрлэсэн ямар хамаа байна? Тэгэхэд чинь үгүй шүү, нэг их шоволзож, “сэтгэл зүйн реализм” гэж нэрлэх санал дэвшүүлсэн байгаа юм. Хоёрт, эхнэр нь америк. Гуравт, Афиногеновыг өнөө, маргаашгүй намаас хөөнө, Зохиолчдын эвлэлээс тууна гэж барим тавим шуугиад байгаа.

-Щукин бол, мэдээж, гарамгай жүжигчин, гэхдээ... хэмээн Вадим зувчуулах маягтай эхлэв.

-Таны “гэхдээг” би мэднэ. Би танд өөр юм хэлэх гэсэн юм. Энэ цааснуудаа гэртээ аваачаад албан ёсны шүүмж болгочих. Тэгээд өөрийнхөө нэрээр гарга.

-Өө, гэхдээ... хэмээн Вадим самгардаж эхлэв.

Альтман түүний үгийг тасдан,

-Та юунд нь зовоов? Энэ бол, гээд мэдээлэл рүү нь заавж, -Нэг зүйл, харин таны бичих юм бол шал өөр зүйл. Бид ямар ч шүүмжлэгчид, түүний дотор танд ч гэсэн захиалж болох албан ёсны шүүмж биччих. Юу? Таныг таньчихна гэж айгаа юу? хэнээс айгаав? гээд Альтман нүдээ сүүмийлгэв.

Вадим алуурчны энэ сүүмгэр харцнаас дотор нь харанхуйлдаг билээ.

-Үгүй чиш, хаанаас даа...

-Зөвлөлт засгийг унагааж, таныг хэрэгт татна гэж айж байгаа юм биш биз дээ?

-За, боль доо, та?! Зөвлөлт засгийг хэн унагааж чадах юм бэ?

-Ёстой, ёстой, тийм учраас бүү ай гээд Альтман дахин нүдээ сүүмийлгэв. -Унагалаа гэхэд таныг олохгүй, санаа битгий зов. Хаант засгийн нууц албаны ажилтнуудаас бид олныг олсон бил үү? Мянга, түмээрээ байсан, тэднээс бид ганц нэгхэнийг л олсон. Ямар ч тагнуулын алба өөрснийхнийгээ илчилдэггүй юм. Өчүүхэн төдий аюул нүүрлэлээ бол давын өмнө тагнуулын мэдээ сэлтийг устгадаг учиртай. Аливаа жинхэнэ тагнуулын алба бол өөрт нь туслаж байсан хүмүүсээ үнэлж, хайрлаж байдаг юм. Тийм учраас, очиж очиж, танд бол санаа зовох юм юу ч байхгүй.

-Надад санаа зовсон юм ч алга л даа, хэр зэрэг нийцтэй байх бол л гэж бодсон юм. Ийм шүүмжийг үзээд, зохиогч нь... ажилтан гэсэн санаа төрж болно...

-Та энэ шүүмжээ сонинд нийтлүүлсэн гэж саная, тэгээд бид түүнийг чинь мөрдлөгт ашигласан бол таныг бас бидэнтэй сүлбэлдсэн гэж сэжиглэх үү? Ямар ялгаа байна? Эсвэл та хэвлэлийн газарт зориулж нууц шүүмж бичиж өгснийг бид мөрдөн байцаалтын хэрэгт хавсаргачихвал яах вэ? Аливаа шүүмж ямар нэг ажиг сэжигний шалтаг болохгүй. Харин яг эсрэг байдаг юм. хүн өөрийнхөө нэрээр ил тод бичнэ гэдэг чинь яг шудрага зүйл. Тэр хүн хэрвээ нууц ажилтан юм бол тийм ил шүүмж бичиж байх хэрэг байх уу?

Тэрээр Вадимаас харц салгалгүй ширтэж байна. Ямар гээч тоглоом вэ?

-Бидний ард байхад танд айх хүн нэг ч байхгүй гэж Альтман тодоос тод өгүүлээд, -Бидний ард байж гэмээ нь, чухамхүү тэнд л та ямар ч аюулгүй байх болно. Тэнд байгаагүй бол, эрхэм Вадим Андреевич та аль хэдийн годройтож арилах байсан... Үүнийг би таныг өөлөх гэж яриагүй байна. Бид таны чин сэтгэлд итгэж байна, дайсантайгаа тэмцэхэд нь намд туслахыг хүсч байгаад итгэж байна. Гэхдээ, Вадим Андреевич, та нэг л болгоомжлоод, нэг л амаа татасхийгээд байгааг бид хэлэхгүй өнгөрч болохгүй. Тэгэх огт хэрэггүй, даан ч хэрэггүй, надад итгэж үзээрэй гэв.

Альтман хэт болгоомжлол гэж юуг хэлж байгааг Вадим мэдэж байгаа учраас лавлаж тодруулья гэсэнгүй. Альтманд хүмүүсийн яриа, ялангуяа бүлэг хүмүүсийн яриа хэрэгтэй байгаа юм. Гэвч одоо хэсэг бусгаараа ярилцана гэж байхгүй, тэр ч бүү хэл, хоёр биентэйгээ

илэн далангүй ярина гэж байхгүй, бүгд ухаан алдатлаа айчихсан юм чинь. Вадим ийм замд орсон бол нэг ч мэдээлэл Альтманд өгч чадахгүй байсан, гэтэл цаадах нь албадна, тэгэхээр үнэн худлаа юм зохиож таарна. Гэтэл мань хүн шүүмж бичиж байгаа, энэ ганц зөв зам. Хэдийгээр далд нэрээр нууц шүүмж бичдэг ч, тэр нь намын албан ёсны байр суурьтай тохирсон, өөрийнхөө нэрээр хаа ч хэвлүүлсэн болох шүүмж. Ершилов бол бүр аймшигтай юм бичиж хэвлүүлж байгаа. түүний муусайн өгүүлэл бас л яллах материал, түүнийхээ төлөө мөнгө авахыг нь яана. мань хүн бол т э д э н д үзэл санааны үүднээс ч гэх үү, үнэ хөлсгүй хийж өгч байгаа. Альтман нэг удаа гарт нь мөнгө атгуулах гэж оролдоход мань Вадим, “Өө, яалаа гэж, заяа нь авахгүй...” гээд гараа хүртэл ардаа нуусан.

-Үгүй, таны ажлын цаг чинь үнэ хөлстэй шүү дээ, та сонинд юм бичсэн бол шагнал авах байсан, энэ мөнгийг тийм шагнал гээд л бодчих. Санаа зоволтгүй, би гарын үсэг нэхэхгүй.

Гэвч Вадим түүний ятгалгад автаагүй, мөнгийг нь ч аваагүй. Тэр нь ч сайн болсон байх. Улс орон, намын өмнө хүлээсэн үүргээ шан харамжгүй биелүүлдэг, шудрага, нэр төртэй хүн болж Альтманд улам үнэлэгдсэн биз. Мөнгө аваагүйг Альтман бас дарга нартаа илтгэж цаадуул нь ч түүнийг үнэлж байгаа байх. Гэхдээ, хэн түүнийг мэдлээ, илтгэх битгий хэл, мөнгөө өөрөө авчихсан ч юм уу. “Гарын үсэг шаардахгүй” гэж хэлээ биз дээ. Өөрийнх нь нэр дээр зарлагадаад авчихыг хэн байг гэхэв... За тэд нар яах л санж вэ. Өөрөө л сэтгэлийн сэвгүй хойно бол оо, өөрөө бол панзны турсага биш, түүнд тийм зоос хэрэггүй, харин Сергей Алексеевичийг юуны учир шоронд хийснийг л мэдэх юм сан.

Вадим энэ тухай Альтманаас асуух гэж хэд хэдэн удаа аман дээр нь гарч ирсэн боловч айгаад чадаагүй. Үнэнийг сонсохоосоо л айсан хэрэг. Та л түүнийг хийлгэсэн шүү дээ гэж хэлвэл яана!

Тэгтэл Альтман өөрөө түүний тухай яриа үүсгэжээ. Нэг ээлжит уулзалтын үеэр Тэрээр Вадимын анхны байцаалтын протоколыг цүнхнээсээ гаргаж өгөөд,

-Унш даа... Энэ хэсгийг хэмээн нэг газар руу хуруугаараа заажээ.

Тэр нь Радекийн тухай онигоо, Эльсбейн, Ершилов, үсчин Сергей Алексеевич энэ тэрийн тухай мэдүүлсэн зүйл нь байв.

-Таны үсчин зөрүүдлээд, бүх юмыг үгүйсгээд болдоггүй, бэлтрэг чинь! Лут зөнөг! хэмээн Альтман Сергей Алексеевичийг байцааснаа санав бололтой хөмсөг зангидан шазвалзав.

Тэгснээ Вадим руу харав.

-Уншчихав уу?

Вадим толгой дохив.

-Маргааш хоёр цагт Лубянкад ирж, пропуск аваарай, энэ үсчинг тантай нүүрэлдүүлнэ.

-Юу?! Юун нүүрэлдүүлэх, яасан гэж? хэмээн Вадим багтран өгүүлэв.

-Яг ингэсний учир гэж гээд Альтман протоколын хэдэн мөрийг зааж, -Та түүний нүүрэн дээр энд гарын үсэг зурсан зүйлээ нотлоорой гэж хэлэв.

-Нөхөр Альтман, яаж тэгж болох юм бэ? гэж Вадим царайчлан өгүүлэв. -Тэр чинь манай ам бүлийн найз, миний үсийг бүр бага байхаас минь зассан, талийгаач ээжийг минь мэднэ, аавыг мэднэ, тийм хүний эсрэг би яаж мэдүүлэг өгөх юм бэ?!

Альтман протокол руу дахиад хуруугаараа хатгав.

-Энд та үнэн юм бичсэн үү?

-Тэгэлгүй яахав.

-Тэгвэл түүнийгээ л нотол.

-Энэ чинь даан ч жол зүйл...

-Магадгүй, тэгэх тусмаа л нотолчих, юунаас айх юм бэ?

-Гэхдээ онигоог би ярьснаас, тэр яриагүй шүү дээ!

-Бас тэгснээ хэлээрэй гэж Альтман жуумалзав.

-Тэгвэл миний мэдүүлэг түүний хэрэгт албан ёсоор орно гэсэн үг үү?

-Тэгсэн үг, юу нь эвгүй байна?

-Гэхдээ миний та бүхэнд хийж өгч байгаатай энэ яаж нийцэх юм бэ?

-Яг нийцнэ.

-Би онигоо ярьчихаад сул явж байхад, түүнийг дөнгөж сонссон тэр хүн шоронд сууж байна. Тэгэхээр би хэн болох вэ? Өдөөн хатгагч!

Альтман хямсайн тамшаалав.

-Ийм сүржин үгний хэрэг юу байна? Ядахаар, хов хоосон үг шүү. Өдөөн хатгасны төлөө бид хатуу цээрлүүлдэг юм, мэдэж аваарай! Тиймээс таны зүгээс өдөөн хатгалга байсан бол бид таныг шийтгэнэ шүү дээ. Харин өдөөн хатгалга байгаагүй. Та онигоо ярьсан, үүнийгээ шудрагаар хүлээсэн. Гэтэл тэр үсчин онигоог сонссон хэрнээ холбогдох газарт мэдээлээгүй төдийгүй, танаас сонссоноо үгүйсгэж байна, бас “Лев Давыдовичгүй бол болдоггүй ээ” гэдэг үгээ үгүйсгэж байна. Тэр яагаад энэ бүхнийг үгүйсгэж байна? “Тийм ээ, энэ онигоог сонссон, түүнийг огт тоогоогүй... Тийм ээ, Лев Давыдовичийг дурссан, одоо түүнийг бүгд л ярьж байгаа юм чинь гээд л хэлчихвэл болох шүү дээ. Тэгээд л гүйцэхгүй юу! Гэтэл үгүй шүү, бүгдийг үгүйсгэж байна. Санамсаргүй тэгэх үү? Хол хэвтэнэ. Эрхэм Вадим Андреевич, та гэнэхэн байна, та утга зохиолынхоо үүлэн дунд л умбаж явна... Гэтэл дайсан тун хорон санаатай. Таны тэр гэмгүй үсчний чинь холбоо сүлбээ хаашаа хаашаа хөвөрч байгааг та мэдэх

ч үгүй, төсөөлөх ч үгүй. Энэ бол гээд Альтман протокол руу заав. -Энэ бол өнгөн дээрээ үнэхээр жол эд, гэхдээ ийм жол юмны цаана маш их юм байж болно. Тэгэхээр та тэр “хүүхэд байхын мэднэ, талийгаач ээжийг минь мэднэ...” гэх мэт нялуун зангаа орхиж үз. Бид ганцхан юм хүсч байгаа: Үсчин үнэнийг, зөвхөн үнэнийг хэлж, энэ үнэнийг юуны учир нууж байгаагаа л бидэнд тайлбарлавал бол оо. Үнэнийг хэлбэл өөрт нь л хэрэгтэй гэдгийг та түүнд бас тайлбарлаж өг.

Тэр хоёрыг Альтманы өрөөнд биш, өөр нэг том даргын өрөөнд нүүрэлдүүлэв. Гэхдээ тэр даргын суудалд одоо Альтман сууж байна. түүний ширээний урдаас тулгасан ширээний нэг талд Вадимыг суулгав.

Альтман Сергей Алексеевичийг оруулж ирэхийг хүлээх зуур нэг юм бичиж сууна. Вадим хонгилд өчүүхэн төдий чимээ гарахад хэрдхийн цочиж, түгшсэн харцаа хаалганаас эс салгана... Ээ бас муухайяа... Хар нялхаасаа танил болсон тэр царайг яаж харна аа, бараг цусан төрөл гэхээр хүнээ худлаа хэлсэн гэж яаж илчилдэг билээ... Ээ бурхан минь! Сергей Алексеевич ийм шалихгүй юмыг юундаа үгүйсгэнэ вэ? Вадимыг өөрийг нь аварч, барьж өгөхгүй гэсэндээ тэр үү? Энэ ч, мэдээж, буянтай хэрэг, гэхдээ тэгэх шаардлага даанч байхгүй, мань хүн ч түүнд шууд л, “Сергей Алексеевич, намайг хөөдөхгүй гэж байгааг чинь би ойлгож байна, энэ бол их буянтай хэрэг, гэхдээ ингэх ямар ч шаардлага байхгүй. Би өөртөө хамаг буруугаа хүлээсэн. Би, зөвхөн Би л тэр онигоог танд ярьж өгснийг би хүлээсэн. Та үүнийг нотлоод хэлчих, би танаас гуйя, энэ бол та бидний хэн хэнд маань чухал...” гээд л хэлж орхино.

Хаалга санаандгүй нээгдэж, хөлөө арай ядан зөөсөн нэг өвгөнийг харгалзагч оруулж ирэв. Вадим түүнийг эхлээд Сергей Алексеевич гэж таньсангүй. Нүүр нь бөөн хөх няц, толгой нь салганана. Тэрээр зүүн гараараа уначих гээд буй өмдөө торгоож, ердийн цагт хайч барьж байдаг зөв гарынх нь хуруунууд хачин хөдлөж харагдана. Вадим агаарт тэмтрэн буй тэр гарыг хараад үнэнхүү балмагдаж, “Тэнгэр минь, хүн өөрөө бараг амьсгаа хураах гэж байхад хүртэл уршил нь хэвээр байх юм даа” хэмээн боджээ.

Альтман Сергей Алексеевичийг нэг хэсэг ширтэж байснаа ханын тэндэх сандал руу дохиж,

-Суу, Феоктистов! гэв.

Сергей Алексеевич анзаараагүй юу, таниагүй юу, Вадим руу харалгүй заасан сандал дээр суув.

-Иргэн Феоктистов! Энэ иргэнийг та таних уу? гэж Альтман ширүүн асуугаад Вадим руу заав.

Сергей Алексеевич толгойгоо арайхийн дээшлүүлж, Вадим руу эргэсхийж харав.

түүний нүдэнд хормын төдийд гэгээ гялсхийгээд унтрах шиг Вадимд санагдав. Өвгөний толгой дахиад гудайчихав.

-Энэ хүнийг таних уу? гэж би асууж байна.

Сергей Алексеевич агаар залгиснаа,

-Танина гэж арайхийн хэлэв.

Өвгөний уруул өмгөнөхөд шүд нь цөмөрчихсөнийг Вадим анзаарав. Уул нь бүтэн шүдтэй л хүн дээ.

-Нэр, овог нь хэн бэ?

-Вадим Андреевич, овог нь Марасевич...

-Тэгвэл та хоёр танил гэдгийг та нотлож байна уу?

-Нотлож байна.

-Ямар нөхцөл байдалд та хоёр танилцсан бэ?

-Эднийхэн надаар үсээ засуулдаг юм.

-Тэгвэл бусад хүн үсээ засуулдаг уу?

-Засуулдаг.

-Та тэднийг бүгдийг нь бүрэн нэр овгоор нь мэдэх үү?

-Тохиолдлынхыг мэдэхгүй, байнгынхыг мэднэ... Эдний аав, Андрей Андреевич, профессор, бүр хувьсгалын өмнөөс...

-Хувьсгалын өмнө юу байсан нь надад сонин биш хэмээн Альтман түүний үгийг тасдав. - Хувьсгалын дараа юу болсныг л ярь. Та Вадим Андреевич Марасевичтэй юу юу ярилцаж байсан бэ?

-Юу ч ярилцаж байгаагүй гэж Сергей Алексеевич толгойгоо өргөлгүй хариулав.

-Тэгвэл энэ тантай?

-Энэ ч надтай юу ч ярьж байгаагүй.

-Тэгвэл улс төрийн онигоо танд ярьж байсан уу?

Сергей Алексеевичийн толгой улам гудайв.

-Үгүй, ярьж байгаагүй.

-За зөрүүдлэж байх шив. Тэгвэл иргэн Марасевичийн үгийг сонсоцгооё. Иргэн Марасевич, та энэ хүнийг таних уу?

Вадим хоолойныхоо чичиргээг арайхийн дарж,

-Танина гэж хариулав.

-түүний нэр, овог?

-Феоктистов Сергей Алексеевич.

-Та түүнийг яаж мэддэг юм бэ?

-Би түүгээр үсээ засуулж, сахлаа хусуулдаг байсан.

-Та түүний хослоо нэрийг яаж мэддэг юм бэ?

-Юу яаж гэж... Би арван таван жил үсээ засуулсан юм чинь, яаж мэдэхгүй байх билээ? Бас манай эцэг ч засуулж байгаа.

Утгагүй, балай асуултнууд, гэхдээ зайлшгүй ингэх ёстойг Вадим ойлгож байв. Альтман тэр хоёрыг яг адилхан үзэж байна. Тэр нь сайн хэрэг. Сергей Алексеевичийн нүдэнд л урвагч болж харагдахгүй бол яасан ч яахав.

-Иргэн Марасевич! Иргэн Феоктистов тантай зөвлөлтийн эсрэг яриа ярьж байсан уу?

-Үгүй чиш, хаанаас даа?! Энэ надтай зөвлөлтийн эсрэг ямар ч яриа ярьж байгаагүй гэж Вадим бувтнав.

-Тэгвэл та түүнтэй?

-Би бас ярьж байгаагүй.

-Өө, тийм бий гэж Альтман худлаа гайхав. -Тэгвэл зөвлөлтийн эсрэг онигоо та түүнд ярьж байсан уу?

-Би Радекийн тухай онигоог ярьсан.

-Ямар Радек, шүүхээр яллуулсан уу?

-Тийм.

-За тэр чинь ямар онигоо вэ?

Вадим нөгөө онигоог дахин ярив.

-Та үүнийг юу гэж дүгнэж байна?

Вадим дуугарсангүй.

-Энэ онигоог юу гэж дүгнэж байна вэ гэж танаас асууж байна, зөвлөлтийнх үү, зөвлөлтийн эсрэг үү?

-Үгүй, энэ чинь онигоо шүү дээ гэж Вадим өчив.

-Яргачин, тагнуул Радекийн манай жолоодогч нөхөр Сталиныг тохуурхсан үгнүүд дахин дахин яригдаж байгаа онигоо зөвлөлтийнх үү, зөвлөлтийн эсрэг үү? гэж Альтман тулгав.

-Зөвлөлтийн эсрэг гэж хэмээн Вадим өөрөөсөө шахаж гаргах мэт өгүүлэв.

-Та тэгээд энэ онигоог иргэн Феоктистовт ярьсан юм уу?

-Тийм.

-Ямар зорилгоор?

-Зүгээр л ярьсан юм.

-Зүгээр л ярьсан гэж Альтман түүний үгийг давтав. -Тэгвэл иргэн Феоктистов хариуд нь яасан бэ?

-Инээгээд, “Лев Давыдовичгүй бол болдоггүй ээ” гэж хэлсэн.

-Ямар Лев Давыдович?

-Бодвол Троцкий биз.

-Феоктистовын энэ хариултыг та юу гэж үзсэн бэ?

-Наргиа үг л гэж.

-Наргиа үг гэдэг чинь юу вэ?

-Түгээмэл үг гэх үү.

-Түгээмэл үг гэдэг чинь юу юм бэ?

-Үгүй яахав, зөвлөлтийн эсрэг элдэв үйл ажиллагаанд Троцкийн гүйцэтгэсэн үүрэг одоо тодорхой байна, шүүн таслах ажиллагаанууд ч бас гэрчилж байна, тэгээд л түгээмэл үг болчихгүй юу.

-Гэхдээ та нар тэр онигоог ноднин, Радекийг баригдахаас өмнө ярьсан шүү дээ.

-Тийм.

-Тэгвэл, таны бодлоор бол, яагаад бүр тэр үед иргэн Феоктистов Радекийг Троцкийтэй холбов?

Вадим дал мөрөө хавчив.

-За яахав гээд Альтман ширээн дээрх цаасаа эмхлэснээ Сергей Алексеевичийг өширсөн харцаар ширтэв. -Иргэн Феоктистов, та иргэн Марасевичийн мэдүүлгийг сонсов уу?

-Сонслоо гэж Сергей Алексеевич шивнэв.

-Тэр танд Радекийн тухай онигоо ярьсан уу?

-Санахгүй байна.

-Та Лев Давыдович Троцкийг дурдаж байсан уу?

-Үгүй, хэзээ ч үгүй.

Альтман хямсалзав.

-Сергей Алексеевич, хэмээн Вадим гэнэт ам нээж, босоод ирэх шахав. -Та яах гэж зөрүүдлээд, яах гэж илт юмыг үгүйсгээд байгаа юм бэ? Би бүх бурууг өөр дээрээ авчихсан шүү дээ, энэ онигоог та биш, би, чухамхүү би танд ярьсан гэдгээ би хүлээчихсэн шүү дээ. Үүнийг би хариуцахаас та хариуцахгүй. Зөрүүдлэх хэрэг юу байна? Намайг хаацайлаа юу? Тэгвэл надад тэр чинь хэрэггүй, ёстой хэрэггүй. Та бидний хэнд маань ч хэрэггүй, та итгэж үз.

Альтман Феоктистовыг харзнав. Гэвч цаадах нь Вадимын үгэнд хэрдхийх бүү хэл, толгойгоо ч өргөсөнгүй.

-За тэгвэл тэмдэглэлээ хийе гэж Альтман өгүүлэв.

Тэрээр нүүрэлдүүлгийн протоколыг нэлээн удаан бичсэний эцэст уншиж сонсгов. Вадим түрүүчийнхээ мэдүүлгийг ёсчлон нотлосон байхад, Сергей Алексеевичийн хариунд асуулт болгоны ард “үгүйсгэж байна” гэсэн үг бичжээ.

-Зөв тэмдэглэж үү? гэж Альтман Вадимаас асуув.

Бүх юм зөв бичигдсэн ч аймаар юм болжээ.

Вадим түгдрэв. Сергей Алексеевич утгагүй зөрүүдлэж өөрийгөө авслах нь. Булуулах нүхээ өөрөө ухаж байна...

-Иргэн Марасевич, зөв тэмдэглэж үү? гэж Альтман дахин асуув. Дуунд нь уцаарлах янз илт.

-Зөв.

-Гарын үсгээ зур.

Альтманы заасан газар Вадим гарын үсгээ зурав.

-Иргэн Феоктистов, бүх юм зөв бичигдэж үү? Хариулаарай!

-Үгүйсгэж байна гэж Сергей Алексеевич шивэгнэв.

-Энд ч “үгүйсгэж байна” гэж л бичсэн байна. Бос!

Сергей Алексеевич сандлаас арайхийн өндийв.

-Наашаа ойрт.

Сергей Алексеевич хөлөө чирсээр ширээ рүү дөхөв.

Альтман протоколыг түүн рүү түлхэв:

-Өөрөө унш!

Сергей Алексеевич уншаад, толгойгоо нэгэнтээ сэгсрэв.

-За, энд гарын үсгээ зур.

Сергей Алексеевич гарын үсгээ зурлаа.

Альтман товчлуураа дарсанд харгалзагч орж ирэв.

-Аваад яв!

Харгалзагч Сергей Алексеевич руу ойртож тохойноос нь дэмнэв.

Яг тэр мөчид Сергей Алексеевич Вадим руу харлаа. Вадимын царай хувхай цайв.

-Даан ч дээ, Вадим Андреевич, Вадим Андреевич...

Альтман ширээ шаав.

-Яриагаа боль! Аваад яв!

Харгалзагч Сергей Алексеевичийг тохойноос нь угз татан түлхээд, өрөөнөөс гаргав.

-Ямар вэ дээ гэж Альтман асуув. -Даруй гурван сар үүнтэй зууралдаж байна. Нүгэлтэй зөрүүд гайхал.

-Бүх юм энэ онигооноос л болж байгаа юм уу?

-Онигоо бол өчүүхэн зүйл, өөр тоймтой юмнууд бий. Ингэхэд, Феоктистов цэргийнхэнтэй танилыг та мэдэх үү?

-Цэргийнхэнтэй юү? Төсөөлөх ч юм алга.

Оржоникизег Улаан талбай дээр ёс төртэй оршуулав.

түүний нас нөгчсөн, оршуулсан тухай олон сонин бүтэн бүтэн нүүр материал нийтлэв. хүнд аж үйлдвэрийн ерөнхий командлагч, ард түмний хайрт хүү, эрхэм нөхөр Серго нас нөгчсөнд улс орон даяараа уйсан гашууджээ. Ийм гарз тохиосонд хямран балмагдсан эрдэмтэд, аж үйлдвэрийн удирдагчид, ажилчид, цэргийнхэн, зохиолчид, жүжигчид, зураачид сонин хэвлэлээр үгээ хэлцгээв.

Дайсан бас яаж ийгээд гараа дүрчихэж. Чеченийн нэг яруу найрагч Оржоникизегийн нас нөгчсөнд зориулсан шүлэг нийтлүүлжээ. Чеченийн зохиолчдын хурал дээр тэр шүлгийг нь магтсан юм байж. Тэгтэл уярч дэвэрсэн найрагч, “Нөхөр Сталиныг нас барахад би бүр илүү шүлэг бичнэ” гэж амлаж. Тэр годилыг арга буюу буудан алжээ.

Оршуулганаас болж Бүгд хурлыг хэд хоног хойшлуулж, хоёрдугаар сарын 23-нд нээв. Одоо бүх юм хэвийн өнгөрөх ёстой. Бухарин, Рыков хоёрыг шууд Бүгд хурал дээрээс баривчлах хэрэгтэй. ТХ-ны бусад гишүүд, орлогчид үүнийг яаж хийдгийг харцгааг. Дараа нь тэр хоёр үзүүлэх шүүх хурал дээр бүх хэргийг хүлээж, тэднээр хэлүүлэх шаардлагатай бүх юмыг ярих болно.

Бухарин хичнээн удаа гэмшсэн билээ? Энэ удаа ч бас гэмшинэ. Ленин түүнийг “лав шиг зөөлхөн” гэдэг байсан хэрнээ яаж “гэрээс”-тээ дурдаж чадсан юм бол? “Лав шиг зөөлхөн” жолоодогч гэж байдаг юм уу? Троцкий түүнийг халирхай амьтан, будлиулагч, бурагч гэж зөв дүгнэсэн. Брестийн эвийн гэрээний үеэр зүүн эсерүүд түүнд Ленинийг баривчилж засгийн газрын шинэ танхим байгуулахыг санал болгосон. Бухарин татгалзах мөрт бүх юмыг Ленинд дамжуулсан. Энэ тухай хэнд ч ярихгүй гэж Ленинд ам өчгөө өгсөн. Гэтэл тэвчилгүй ам алдчихсан. Ленинийг нас барснаас хойш энэ тухай жигүүр, бүлгийн тэмцэл юунд хүргэдгийг хар гэх ухаантай олон нийтийн өмнө цуурсан. Харин одоо бараг хорин жилийн дараа тэр явдлыг нь Ленинийг баривчлах тухай эсерүүдтэй нууцаар тохиролцож байсан хэмээн мань хүн түүнд ял болгон тулгасан. Өөрөө хүлээн зөвшөөрч байсан юм чинь! Эсерүүд ТҮҮН РҮҮ ирээгүй мөртлөө Бухарин руу очсон байгаа юм. түүнд тийм санал тавиагүй атлаа Бухаринд тавьсан байгаа юм. Бухарин татгалзсан эсэх нь бүү мэд. Зөвшөөрчихөөд тэр нь бүтээгүй ч юмсан уу. Хэрвээ татгалзсан бол айсан хэрэг. Ленинд ярьсан юм уу? Баталгаа нь хаа байна? Ленин үхсэн. Урт хошуу хүзүү орооно гэдэг энэ дээ. Бухарин Ленинийг баривчлах гэж байсныг одоо нийт ард түмэн мэдэж авах болно.

Хөнгөмсөг зан уу, айварлалт уу? Магадгүй. Гэхдээ чи хөнгөмсөг айварлагч юм бол удирдлагын дотор манлайлах гэж бүү зүтгэ. “Намын хайрт хүү”-гийн дүрийг бүү булаацалд. Тэрээр Бухаринаас ангижрахыг аль эртнээс хүссэн билээ. Хориод оны дундуур, зинovieвтын сөрөг хүчнийг бут цохисны дараа Тэрээр баруунтныг задлана, Рыковыг Бухаринаас салгана гэж найдаад Рыковт, “Алексей, хоюулаа гар нийлж үзэх юм биш үү” гэж битүүхэн хэлсэн. Алексей тэгэхэд тоогоогүй, одоо гор нь гарч байгаа нь энэ дээ.

Хоёрхон сарын өмнө, арван хоёрдугаар сарын Бүгд хурал дээр Бухарин их даналзаж байсан.

Ежов Рыков тэр хоёрыг троцкий-чуудтай эвсэлдсэн, тэдний алан хядах үйл ажиллагааны тухай мэдэж байсан гэж буруушаасан. Тэгэхэд Бухарин Ежов руу,

-Дуугаа тат! Дуу! Дуу! гэж хашгичсан шүү.

Юундаа тэгж мангарлаж хашгираав?! түүнийг хэн ч дэмжээгүй. Зөвхөн Оржоникизе л Ежовыг самууруулах санаатай хэдэн асуулт тавьсан. Самууруулж чадаагүй. мань хүн тэгэхэд,

-Шийдвэр гаргах гэж яараад яахав, нөхөд минь. Жишээлбэл, мөрдөх байгууллагынханд Тухачевскийн эсрэг материал бас байсан, гэтэл бид үзэж учрыг нь олсон, одоо нөхөр Тухачевский ажлаа тайван хийж байна гэж хэлсэн.

Тэгээд тогтоолын төсөл санал болгосон: “Рыков, Бухарин хоёрын асуудлыг дуусаагүй гэж үзсүгэй. Шалгалтыг цаашид үргэлжлүүлж, хэргийг ТХ-ны дараачийн Бүгд хурлаар шийдэхээр хойшлуулсугай”.

Арга саам хийсэн нь тэр. Яах гэж тэгэв? Яах юу байхав, эхлээд нэгдүгээр сард Радек-Пятаков-Сокольниковын хэргийг шүүн таслах хэрэгтэй, тэгж байж дараа нь Бухаринтай эргэж тооцоо хийх гэж тэр. Далиманд нь Тухачевскийг тайвшруулсан хэрэг.

Төслийг тэр чигээр нь батлажээ. Нэгдүгээр сарын шүүн таслах ажиллагаан дээр бүх юм нотлогдож, Бухарин, Рыков хоёрын нэр орон даяар төдийгүй, дэлхий дахинаа цууриатлаа. Бухаринтай баруунтны сөрөг хүчинд хамт зүтгэж явсан нөхөд, Улаан эрдэмтдийн хүрээлэнд суралцаж байсан шавь нарыг нь байцаасан протоколыг сүүлийн хоёр сарын турш өдөр болгон түүнд гэр рүү нь хүргүүлж байгаа билээ. Зөвхөн хоёрдугаар сарын 16-ны ганц өдөр гэхэд л хорин тийм протокол хүргүүлсэн. Уншиж байг. Үүний хажуугаар Сокольников, Пятаков, Радек энэ тэртэй, бас шавь нартай нь, жишээлбэл, Астровтой удаа дараа нүүрэлдүүлж байгаа.

Энэ бүхний дүнд Бухарин бүрмөсөн уймарч гүйцсэн. Өлсгөлөн зарлаж, түүнийг буруутгахаа больж цайруулахаас нааш Бүгд хуралд оролцохгүй гэж мэдэгдсэн. Хэзээний гэнэн дамшиг, одоо ч ялгаа алга. Гэрийн өлсгөлөнгөөр хэнийг айлгах гээ юм бол? Өлсгөлөн зарлахыг шоронгийн дэг зөрчсөн хэрэг, хувьсгалын эсэргүү ажил явуулгаа шоронд үргэлжлүүлж байгаа хэрэг гэж үзэж бай гэж мань хүн тухайн үедээ Ежовт үүрэг өгч байсан. Гэтэл орон гэртээ, залуухан авгайнхаа бөөрөнд өлсгөлөн зарласан байх юм. түүний үнэхээр өлсөж байгааг хэн нотлох юм бэ?

Ингэж өлсгөлөн зарласных нь төлөө мань хүн түүнийг шийтгэсэн. ТХ-ны Бүгд хурлаар хэлэлцэх хэргийн эхэнд “Бүгд хуралд өлсгөлөн зарласан Бухарины намч бус авирын тухай” асуудал оруулсан. “Н.Бухарин, А.Рыков нарын тухай” асуудлыг зөвхөн хоёрдугаарт оруулсан.

Бухарин хаачих вэ дээ, Бүгд хуралд ирдгээрээ ирсэн. Хэдийгээр өлсгөлөнгөө зогсоогоогүй ч, ямар ч атугай ирсэн. Бүгд хуралд оролцогсод түүнд нүүр өгөөгүй. мань хүн гярхай ажигласан, хоёрхон хүн түүнтэй мэндэлсэн. Арми командлагч Уборевич, Акулов хоёр. Акулов, зүгээр ч үгүй, нэг юм хэлсэн, бодвол урам хайрлаа биз... Гэтэл Бухарины тухай мэдүүлгийг тэр хоёрт бас давхар хүргүүлж байсан шүү дээ. Тэгэхээс тэгэх гэж мэндэлж байгаа нь тэр.

Дараа нь Бухарин сандлуудын хоорондох чөлөөнд муужирч ойчсон. Өлсөөд ухаан алдаж байгаа дүр үзүүлж байгаа нь тэр. Ингэтлээ сульдсан юм бол хурлын танхимд яаж ирээв? Эсвэл “өвчний учир” асуудлыг хойшлуулна гэж горьдоо юу? Үгүй шүү, хойшлуулахгүй.

Мань хүн түүн рүү очсон.

-Николай, чи хэнд өлсгөлөн зарлаа вэ, намын ТХ-нд уу? Наад байж байгаа царайгаа хараач, бүр яс арьс болчихож. Өлсгөлөн зарласан буруугаа хүлээж Бүгд хурлаас уучлалт гуй.

-Та нар намайг намаас хөөх гэж байгаа юм бол яах гэж уучлалт гуйх вэ? гэж Бухарин хариулав.

-Чамайг хэн ч намаас хөөхгүй. Николай, бос, тийшээ оч! Бүгд хурлаас уучлалт гуй, чи тусгүй юм хийсэн шүү.

мань хүн түүнд ингэж хариулсан. Аяархан хэлсэн. Өөр хэн ч сонсоогүй. Бухарин бол сонссон. Тэгээд дамшиг чинь үнэмшихсэн, дорхноо сэргэж, шалан дээрээс босоод өлсгөлөн зарласандаа уучлалт гуйсан. Элдэв муугаар буруутгасан тухай нэг юм үглээд байсан, гэхдээ л уучлалт гуйсан. Индрээс бугаад нөгөө суудлийн чөлөөндөө очоод шалан дээр суучихсан. Яах гэж тэр вэ?

Яг тэр чигээрээ шалан дээр сууж байгаад Ежовын илтгэлийг сонссон. Ежов энэ удаа түүнийг алан хядах үйл ажиллагаа явуулсан, ордны эргэлт хийхээр бэлтгэсэн, троцкийчууд, зиновьевчуудтай эвсэлдсэн, нударганчуудын бослогыг зохион байгуулсан, ЗСБНХУ-ыг хөрөнгөтөнд худалдсан, Кировыг алсан гэх мэтээр буруутган яллав. Бухарин шалан дээр суугаад, Ежовыг чимээгүй сонсох зуур, өөрийг нь мань хүн өмгөөлөх байх гэж горьдон түүнийг байн байн хараачлана. Гэтэл мань хүн биш, Микоян үг хэлж, Бухарин, Рыков хоёрт нам, ард түмний дайсан гэж улс төрийн үнэлэлт өглөө. Хуралдаан үүгээр өндөрлөжээ.

Дараа нь шалгаж үзвээс, Бухарин гэртээ оройн хоолоо идэж, намаараа сайрхаж байгаад Бүгд хурал дээр гэдэс цаггалан буцаж ирж, мань хүн хэзээ аминд нь орохыг хүлээн, ТҮҮН РҮҮ дахиад царайчлан харж эхлэв.

Үгүй шүү, хонгорхон Бухарчик минь, нөхөр Сталиныг чи өөрөө “телефонтой Чингис хаан” гэж нэрлээ биз дээ, тэгвэл Чингис хаанууд чинь өршөөл үзүүлэхээ яардаггүй юм.

Маргааш нь Молотов, Каганович хоёр үг хэлж, ёстой хайр найргүй балбав. Ухаан гүйх нь удаан Молотов бүр,

-Хэргээ хүлээцгээ, баривчлана шүү. Фашист хэвлэлүүд манай шүүн таслах ажиллагааг өдөөн хатгасан явуулга гэж дайрч байгаа. Та нар буруугаа үгүйсгэснээр фашистын хөлсний барлаг гэдгээ л зөвхөн нотлоно, өөр юм байхгүй гэж сэргэлэнтэж байна.

Бухариныг хэн ч дэмжсэнгүй. мань хүн үг хэлээгүй. Харин Бухарин, Рыков хоёрын тухай шийдвэрийн төсөл боловсруулах комисс байгуулах санал тавьжээ. Тэр ёсоор болгож. Гучин зургаан хүнтэй комисс, дарга нь Микоян.

Комиссын хурал дээр хорин хүн үг хэлжээ. Ежов, Буденный, Мануильский, Шверник, Косарев, Якир зургаа буудан алах ёстой гэж санал тавьж. Постышев, Косиор, Петровский, Антипов, Николаева, Шкирятов, Хрущев нарын долоон хүн буудан алалгүй шүүхэд шилжүүлэхийг санал болгож. Комиссын олонхи нь, түүний дотор Крупская, Ульянова энэ тэр түүний буюу х а м г и й н “з ө ө л х ө н” санал-намаас хөөж, шүүхэд өгөхгүйгээр хэргийг нь ДЯАК-д шилжүүлэх саналыг дэмжицгээж.

Хэргийг ДЯАК-д шилжүүлнэ гэдэг бол тэр хоёрыг тийш нь шилжүүлнэ гэсэн үг.

Тэр даруй, хоёрдугаар сарын 27-нд Бухарин, Рыков хоёрыг Бүгд хурал дээрээс баривчлав.

Нөхөр Сталин энэ Бүгд хурал дээр гуравдугаар сарын 3-нд илтгэл тавив. Тэрээр,

-Хорлон сүйтгэгчид, эвдэн бусниулагчид, тагнуулчид, гадаад улсын төлөөний этгээдүүд улс орны бүх байгууллагад нэвчин орсон байна. Эдгээр байгууллагын удирдлага алмайран сууцгааж байсан байна.

Капиталист хүрээлэл байгаа цагт хорлон сүйтгэгчид, тагнуулчид, эвдэн бусниулагчид, алуурчид манайд байсаар байх болно.

Өнөөгийн хорлон сүйтгэгчид, эвдэн бусниулагчдын хүч тэдний өвөрт байгаа намын батлаханд байна.

Манай хүмүүсийн сул тал нь тэд намын батлахтай хүнд сохроор итгэдэг явдал юм.

Хорлон сүйтгэгчид ажил дээрээ тогтмол амжилт үзүүлж байж ч мэднэ, хорлон сүйтгэх үйл ажиллагаагаа дайн болтол хойш тавьж байгаа нь тэр гэхчилэн илтгэжээ.

Нөхөр Сталин ард түмнийхээ эсрэг арван жилийн өмнө эхэлсэн дайнаа гучин долоон оны хоёр, гуравдугаар сарын Бүгд хурал дээр ийнхүү албан ёсоор зарлажээ.

Эрдэмтдийн тооцоолсноор 1937 оны эхэнд шорон, хорих лагерьт таван сая хүн хоригдож байжээ. Гучин долоон оны нэгдүгээр сар, гучин найман оны арван хоёрдугаар сарын хооронд дахиад долоон сая хүн баривчлагджээ. Тэдгээрээс нэг саяыг буудан алж, хоёр сая нь хориход амь насаа алджээ.

Шарлийн эцэг, эх Алжирт сууцгаана. Эцэг нь тэндхийн Францын захиргаанд том албатай. Тэд нар бэрдээ захиагаар халуун дотно мэндчилгээ дэвшүүлж, түүнийг захиагаар үнсэнэ. Шарль хариуд нь Викагийн нэрийн өмнөөс мөн тийм дотно үгс, үнсэлт илгээнэ.

Өглөөдөө Сюзанн унд бэлтгэж өгнө. Кофе, сүү, цөцгийн тос, тэргүүн боов, жимсний чанамал. Шарль ундныхаа дараа өрөөндөө орж ажиллана. Үдийн хоол бэлэн болж, ширээ засчихсанаа Сюзанн нэг цаг өнгөрсхийгээд хатагтайдаа илтгэнэ. Тэр хоёр оройн хоолоо голдуу ресторанд идэцгээнэ. Вика эндхийн гуанз, рестораныг шүтэх нь халаг. Цэрвэж бишүүрхэх явдалгүй, хэн хүнгүй өөдөөс инээмсэглээд цаанаа л нэг өөриймсөг. Москвад ресторанд орно гэдэг бол том үйл явдал, харин энд бол парисынхны амьдралын салшгүй нэг хэсэг. Хаалгачин, өлгүүрчин энэ тэр гэж байхгүй, пальтогоо дугуй өлгүүрт өлгөчихнө, эсвэл авч ороод хажуугийнхаа сандал дээр тохчихно, танхимын зохион байгуулагч үүдэнд тосч, сэтгэлд таарсан суудалд аваачиж суулгана, танихгүй хүн нэмж суулгахгүй, үйлчлэгч нар уриалгахан бөгөөд дуулгавартай, хүн болгонд хоолны цэс өгнө, зоргоороо харж, сонго... Хэдхэн сарын дотор Вика явах, очих дуртай газартай болжээ. Жишээлбэл, ресторан “Ротонда”, тэндээс гараад Распайн цэцэрлэгт гудамжаар алхлах шиг сайхан зугаалга унтахын өмнө байхгүй. Гэхдээ тийшээ тэр бүр явах нь үгүй, “Ротонда” ресторан руу очих, Сена мөрний эрэг хавиар очих уу, эсвэл өөр нэг танихгүй газар очих уу гэдэг нь Шарлийн тэр өдөр хаана ажилтай яваагаас шалтгаална.

Шарль нэг удаа, өнөө орой “Closerie des Lilas”-д очно, тэнд хүнтэй уулзах ёстой юм гэж.

-Чамд сонин байх байх, алдар цуутантай тааралдаж болно, Хемингуэй тэнд орох дуртай, голдуу лангууны ард сууж байдаг юм, гэхдээ одоо мань хүн Испанид яваа...

Тэр кафе Монпарнасын цэцэрлэгт гудам, Avenue de L'Observatoire хоёрын уулзвар өнцөг дээр байдаг юм санж. Шарль Викад одон орны судлалын хүрээлэнг үзүүлэх гэж бодсон юм байж. Гудамжны нэр нь ч түүнээс үүсгэлтэй аж. Гэвч хүрээлэн хаалттай байжээ.

“Closerie des Lilas”-“Голт борын гацаа” хэмээх энэ кафе Викад сайхан санагдав. Тохилог ч юм, хөл хөдөлгөөнтэй ч юм. Орох гарах хүмүүс бие биенээ таних нь элбэг, Шарльтай байсхийгээд л хэн нэгэн мэндлэнэ. Нэг танил сэтгүүлч нь тэдэн рүү даллаж, мань хоёр түүний ширээ рүү очиж суув. Вика хаа нэгтээ онцын түвэггүй үг, өгүүлбэр хавчуулж, тэдний ярианд оролцоно. Францаар ярихад сайхан оргиод, мань хүүхэн хэрхэндээ өөрийгөө тоожээ.

Тэд оройн хоолоо дуусгах тийшээ хандаж, Вика төгсгөлд нь амтат идээнээс юу авахыгаа сонгох зуур цэсний дээгүүр санаандгүй хартал харц нь тун сая орж ирсэн нэгэн ноёнтон дээр туслаа.

Жар эргэм насны, дунд зэргийн нуруутай, эвэр хүрээтэй шилтэй, цохон дээрээ гүнзгий босоо атираатай ноёнтон. Тэнд байсан хүмүүс түүнийг тосон мэндлэх мэт танхимд хормын төдийд чимээ намдсаны учир Вика тэр ноёнтынг анзаарсан байж ч магадгүй. Аргагүй л дорвилог бөгөөд эрэлхэг царайтай эр.

Тэрээр сул сандал дээр пальтогоо тавьж, орчныг эргэлдүүлэн харснаа, Шарлийг үзэнгүүт тэдний ширээ рүү ирж, нийтэд нь мэхсхийв.

Шарль босч, тэр хоёр гар барилцлаа.

-Миний номны тухай өгүүлэл нийтлэсэнд талархаж байгааг минь редактордоо уламжилж өгөөрэй.

-Нийтлэхээс өөр яахав, месье Жид, ёстой сайхан ном юм чинь.

-Тэр болгон хүн тэгж бодохгүй байгаа.

-Тэднүүс Оросыг мэдэхгүй юм чинь. Тэднүүс Оросыг тань шиг харж, тань шиг ойлгож чадаагүй улс. Би тэнд хэдэн жил болсон учраас таны гярхай ажиглалтыг үнэхээр бахдаж байна. Золгүй улс. Тэнд байсан ганц олигтой юмыг нь би аваад ирсэн...

Тэрээр Викаг сайхь ноёнтонд танилцуулав.

Жид түүний гарыг эелдэгхэн атгаж, найрсаг инээмсэглэв.

-Виктория-Ялалт! Энд ирсэн чинь үнэхээр таны ялалт. Хатагтай таныг Оросын тухай миний номыг унших анхны орос эмэгтэй болно гэж найдаж байна. Гэхдээ номын доторхи бүх юм таны сэтгэлд нийцнэ гэж яаж итгэх сэн билээ.

-Нийцэхгүй юм гарахгүй! гээд Вика ялдам инээмсэглэв. -Манай нөхөр таны номыг шагшин магтаж, надад зөндөөн ярьсан. Бид хоёрын дур сонирхол дүйдэг юм.

Шарль гэртээ ирсэн хойно,

-Орчин үеийн Францын зохиолчдоос миний хамгийн хайртай зохиолч бол Андрей Жид. Чи түүнийг хэдтэй гэж бодож байна гэж асуув.

-Жар эргэм.

-Жаран наймтай. түүний ном Москвад чамд тааралдаж байсан уу?

-Үгүй гэж Вика үнэнээ хэлэв.

-Орост түүний ном их хэвлэгдсэн. Тэр ч атугай зохиолын эмхтгэл ботиуд гарсан. Өөрөө ЗСБНХУ-ыг ихээхэн талархагч байсан юм.

Шарль тавиур дээрээс нэг ном авч тэмдэглэсэн хуудсаа нээв.

-Тэрээр ЗХУ-д очихынхоо өмнө ингэж бичиж байсан юм:

“ЗХУ-ыг хайрлан бахдаж байгаагаа би гурван жилийн өмнө ярьж байсан. Тэнд бидний сэтгэл зүрхийг горьдлогоор бялхуулсан урьд хожид хэзээ ч байгаагүй туршилт хэрэгжиж, тэндээс

бид аврага том дэвшлийг хүсэн хүлээж, тэнд бүх хүн төрөлхтөнийг эзэмдэн дагуулах их дуудлага үүсэн төрж байсан юм. Бид соёлын хувь заяаг бодол зүрхэндээ ЗСБНХУ-тай холбон үзэж байлаа. Бид энэ улсыг хамгаалах болно”.

Шарль номноос хараа салгаж,

-Би Жидийн тухай нэлээн том өгүүлэл тэрлэж байгаа учраас түүний гучаад оны эхээр, “Хэрвээ ЗСБНХУ-д миний амь насны хэрэгцээ гарлаа гэвэл би амь насаа тэр даруй тушаана” гэж хэлж байсныг нь тодхон санаж байна гэснээ нөгөө номоо дахин нээлээ.

-Харин тэндээс буцаж ирэнгүүтээ юу гэж бичсэн нь энэ байна:

“Ямар ч асуудлаар ганцхан үзэл бодол байх ёстой гэж ЗСБНХУ-д нэгэнт үүрд шийджээ... Юу мэдэж байвал зохих, юу бодох, юунд итгэх ёстойг өглөө бүр “Правда” мэдээлж байна... Чи нэг орос хүнтэй ярьж байгаа хэрнээ бүх хүнтэй ярьсантай ялгаагүй гэж бод. Ийм ухамсрыг хүүхэд ахуйгаас нь төлөвшүүлж байна. ЗСБНХУ-д хувь хүний сэтгэлгээ өөрийн гэсэн нүүр царайгаа гээх хандлага бүх нийтийг хамрах шинжтэй байгааг дэвшил гэж үзэж болох уу?.. Ухамсар ингэж хүлэгдсэн, дарамтлагдсан, боолчлогдсон, айдаст автсан ийм орон Гитлерийн Германаас өөр байхгүй. Хүмүүсийн тэргүүн хэзээ ч ийм дор ортлоо гудайж байгаагүй”.

Шарль Вика руу харлаа.

-Тийм ээ, хүний урманд гац үг зөрөх зүрхтэй толгой байхгүй гэж Вика оросоор хэлэв. Тэрээр одоо хэр оросоор боддог нь хэвээр учир шууд францаар ярихад хэцүү л дээ.

-Засаглалын тухай түүний эрэгцүүлэл саяныхаас дутуугүй сонин шүү, чи сонс доо: “Пролетарийн диктатур биш нэг хүний диктатур байна. Улс дотроо сөрөг хүчнийг устгана гэдэг бол алан хядлага руу уриална гэсэн үг. Амаа таглуулж, аль ч талаасаа дарамтлуулсан ард түмэн эсэргүүцэх боломжгүй болжээ. Барлаг боолын сэтгэлгээтнүүд, зуйрган бялдууч мэтийн адгийн шаарнуудын ёстой нар нь гарч байна. Энэ хүмүүс хичнээн өчүүхэн, хичнээн увайгүй байна, Сталинд төдийчинээ үхэр нохой мэт үнэнч байна. Шилдгүүд нь алга болж байна, тэднийг үгүй хийж байна. Сталиныг тойрон хүрээлэгчдийн дунд шинэ санаа оноо гаргах хүн байхгүй учраас удахгүй түүний үг үнэн зөвийн ганц зарлиг болно. Дарангуйлагч өөрийгөө толгойтой хүнээр бус, үг дуугүй хүлцэн дагагчдаар хүрээлүүлдэг нь дангаар ноёрхогч ёсны нэг онцлог юм хойно доо”.

Тэрээр номоо буулгаж,

-Чамд залхуутай байна уу? гэв.

-Өө, хаанаас даа! Би анх удаа ийм юм сонсож байна... Үгүй ээ, өөрөөр хэлбэл, би үүнийг мэднэ, ойлгоно, гэхдээ мань хүн гайхалтай онож томъёолсон байна.

-Нээрэн, мань хүн мастер шүү. Бас нэг юм байна: “Хилийн чанадад бүх юм ЗСБНХУ-ынхаас гарцаагүй дор гээд ард түмэндээ итгүүлчихэж. Тийм учраас ажилчин хүн толгой дараалан төр засагтаа баярлана, түүнээс улбаалан “давуугаараа омойтох” янзтай. Тэдний хувьд бол

Зөвлөлтийн хил хязгаараас цааш харанхуй бүдүүлэг ертөнц эхлэнэ. Биднийг Сочид далайн эрэг дээр очиход, тэнд усанд орж байсан улс Францад иймэрхүү зүгийн ч юм байхгүй гэж биднээр хэлүүлэх гээд байсан. Францад эндхийнхээс хавьгүй дээр газар бишгүй бий гэдгийг бид ёсыг бодоод хэлээгүй”.

-Энэ чинь манай бардам орос зан яг мөн. Би Сочид очихоороо нэг болсон. Сувилалын газар байгаа хүмүүст бол дажгүй, бусад нь бол наранд ээх газар хоттой хонь шиг бөөр бөөрөөрөө шахцалдаад хэвтгээд байна шүү дээ. Тэгээд нэг муу гуанзанд орох гэж хэдэн цаг зогсоно гэж Вика өгүүлснээ,

-Жид орос хэлтэй юү? гэж асуув.

-Ганц ч орос үггүй.

-Мөн ч гярхай ажигласан байна шүү, уул нь түүнд хамаг сайнаа л шилж үзүүлсэн дээ, манайхан гадаадын хэнийг ч бай, эвтэйхэн малладаг юм чинь.

Шарль ном руугаа толгойгоо шургуулах нь халаг,

-Бас нэг сонин юм ажигласан байна гэв:

“Ховоос хамгаалах хамгийн сайн арга бол өөрөө ховлох. Ховлохыг иргэн хүний буянт үйлсийн зиндаанд хүртэл өргөсөн байна”.

Вика сэрдхийн час улайж, түүнээ нуух санаатай буйдан сандал дотроо хэд займчив.

Шарль гайхсхийн түүн рүү харав.

-Өрөөсөн хөл чилчихэж хэмээн Вика хөлөө сольж ачаад, -Цааш нь унш даа, ёстой сонин байна гэв.

Биеэ барьж дөнгөсөн нь яамай, ээ тэнгэр гэж. Юунд тэгтлээ эмзэглэх нь энэ вэ? Х а м а г ю м ард хоцорсон шүү дээ. Шарок, Маросейка, нөгөө гарын үсгээ зурсан заяагүй бичиг, баталгаа энэ тэр бүгд хилийн цаана хоцорсон... Нэмэрт нь, “хил цоожтой” байгаа. Тэгсэн хэрнээ ганц тэр үгнээс аюулын амьсгаа сэнхийжээ.

-Бас сонс доо: “Эд бараа нь гэж хариу байхгүй. Москвагийн дэлгүүрүүдийн цонхны үзүүлэнг хараад гутран цөхрөхөөс өөр аргагүй”.

-Наадах чинь ч яг шүү хэмээн Вика инээд алдав.

-Цаашилбал: “Францын хэсэг уурхайчид ЗХУ-аар аялах зуураа нэг уурхай дээр очиж, зөвлөлтийн уурхайчдын оронд нөхөр ёсоор ажиллахдаа, төдийлөн улайж махраагүй мөртлөө өөрснөө ч мэдэлгүй стахановч нормыг биелүүлчихжээ. Зөвлөлтийн ажилчин бол хүний ёсоор аж төрөх нөхцөлөөр гачигдсан, эсэргүүцэх эрх, тэр ч бүү хэл, хүнд сонсдож дуулдахаар гомдол мэдүүлэх эрх байхгүй хавчигдсан, дарлагдсан, туйлдсан амьтан болж хувирчээ...”

Шарль номоо ширээн дээр тавьж, эелдэгхэн инээмсэглээд Вика руу бөхийж гараас нь барив:

-Ийм юм уншаад урмыг чинь хугалчихав уу?

-Яаж гэж тэр вэ, хонгор минь?

-Эх орныхоо тухай ийм юм сонсоход юу нь сайхан байхав. Оросууд чинь мундаг эх орончид биз дээ?

-Би орос нь орос л доо, гэхдээ Зөвлөлүүд надад ёстой пад байхгүй.

-Энэ номны тухай том өгүүлэл бичиж байгаа гэж би чамд хэлсэн хэмээн Шарль жуумалзав. - Би чинь Зөвлөлт Оросоор мэрэгжсэн хүн гэгддэг шүү дээ.

-Чи мэрэгшсэн хүн яг мөн юм чинь гэж Вика өгүүлэв.

-Манай зүүнтнүүд надад их дургүй... Үгүй, тэгж яривал, тэд нар Жидэд ч бас муу.

-Коммунистууд уу?

-Коммунистууд, бас тэдэнд ойр дөт байдаг хүмүүс. Ромен Роллан, Луи Арагон, Мальро энэ тэр, өөр бас олон хүн бий. Эд нар авьяаслаг хэрнээ харалган, гэнэн хүмүүс. Чи дургүйцэхгүй бол дахиад хэдэн мөр уншъя.

-Хаанаас даа...

мань хүүхэн хэдийгээр жаахан залхаж, ямар ч ойлголт байхгүй Арагон, Мальро гэгчдийн тухай сонсож суухад уйтгартай ч гэсэн тэсэхээс яахав. Тэрээр Шарлийн хувьд байнгын шимтэн сонсогч нь байх ёстой, энэ бол тэдний цаашдын аз жаргалтай амьдралын нэг нөхцөл.

-За, тэгвэл хар даа, ийм нэг сонин юм байна хэмээн Шарль үргэлжлүүлэв. “Уран бүтээлчээс, зохиолчоос гагцхүү дуулгавартай байхыг л шаардана, тэгвэл бусад нь аяндаа бүтнэ. Оюун ухаан иймэрхүү байдалд царцахаас илүү аюултай юм соёлын хувьд байхгүй. Аль нэг туушт үзэлтнээс хараат байдалд орсон урлаг, түүний номлол хичнээн дэвшилттэй байлаа ч мөхөх тавилантай. Хувьсгал уран бүтээлч хүнд хамгийн түрүүнд эрх чөлөө өгөх ёстой. Эрх чөлөөгүй бол урлагт утга ч байхгүй, ач холбогдол ч байхгүй. Том уран бүтээлч, том зохиолч бол засгийн үзлийг үл дагагсад байх ёстой. Тэд бол урсгал сөрөгчид”. Мундаг хэлж байна шүү!

-Мундаг хэлж!

-Гэхдээ Жид өөдрөг үзэл бодлоор номоо дуусгасан: “ЗСБНХУ гэж түүнийг удирдаж байгаа хүмүүсийг би хэлж байгаа юм. Бүхэл бүтэн улс орны алдаа ч үнэнийг гутааж чадахгүй. Сайн үйлс дэлгэрнэ гэж найдацгаая. Эс тэгвээс хайр хүндлэл хүлээвэл зохих энэ сайхан баатарлаг ард түмнээс дамчид, алуурчид, тэдний золиосноос өөр юу ч үлдэхгүй”.

Вика гараа тосч,

-Аль вэ, би харъя гэв.

Тэрээр хэдэн догол мөр дуудан уншсанаа хуудсаа эргүүлж, амандаа хэсэг уншиж үзээд,

-Хүүе, би бүгдийг нь, эсвэл бараг бүгдийг ойлгодог болчихож. Зарим нэг үгийг л мэдэхгүй байна гэж баярлан дуу алдав.

-Чи мадемуазель Ириантай ярилц, наад номыг чинь чамд гэрийн даалгаварт өгч уншуулж байг.

Мадемуазель Ирина гэж түүний франц хэлний багш, долоо хоногт хоёр удаа ирж хичээл заана. Вика Нелли Владимировагийн сургаалийг зөрчсөн нь энэ. Ирина цагаач язгууртны гэр бүлээс гаралтай юм. Орост төрсөн, Крым, Турк, Болгараар дамжиж явсаар эцэст нь Францад суурьшжээ. Сорбоннын их сургууль төгссөн. Шарлийн хэлснээр бол Парисын хамгийн сайн багш. Хүмүүжил сайтай, нүдэнд дулаахан, эелдэг хүүхэн. Хичээл номоо ёсоор нь заахаас биш, элдэв хөндлөнгийн сэдэв рүү хальтрахгүй, ялангуяа орос цагаачдын ажил явдлын тухай Викад огтхон ч эс дурсана. Зөөлөн аяглаж, инээмсэглэж байгаад нэг үгийг арав, хорь ч хамаагүй давтан хэлүүлнэ, гэрийн даалгавраар дарж өгнө. Заримдаа магтана. Вика амьдралдаа анх удаа махран ном үзэж байгаа нь энэ. Шарль долоо хоног бүр хоёр удаагийн хичээлийн хөлс бүхий дугтуйг мадемуазель Иринад зориулан үлдээнэ.

-Маш сайн байна, би ч бас энэ зохиолчид их дуртай хэмээн Ирина Андре Жидийн номоор хичээллэхийг дэмжиж, -Дараачийн хичээлд эхний таван хуудсыг орчуулаад ирээрэй гэжээ.

Вика долоо хоногт хоёр удаа Сюзаннтай зах орж, тэр тоолондоо нүд нь орой дээрээ гарна. Ховор зэвэр Москвад дассан болохоор орчлон дээр ийм элбэг дэлбэг баялаг байдагт итгэж ядна.

Үдийн хоолны дараа Шарль сонинхоо газар руу очно. Тэрээр улс төрийн тайлбарлагчийн албатай, өдөр бүрийн “тайлбарлагчийн зурвас”-ыг эрхлэн гаргана, ажил ихтэй, заримдаа, ёс юм шиг гэнэтхэн хэд хоногоор Лондон, Берлин, Ром энэ тэр гээд гадагшаа яваад өгнө. Викад утсаар амжуулж хэлээд, ажил дээрээсээ шууд явчих нь ч бий. Өнгөрсөн хугацаанд Тэрээр хоёрхон ням гаригт л Викад зориулж цаг гаргасан. Нэг удаа Тахир татуугийн ордонд аваачсан, тэндхийн сүм, Наполеоны улаан боржин бунханг үзүүлэх гэж тэр, нөгөө удаа нь Версаль руу очиж үзэцгээжээ.

Вика хичээлгүй, зах явдаггүй өдрөө хотоор ойр зуур зугаална. Эхэн үес дэлгүүрийн цонхон дээр очиж юм хардаг байж. Гэтэл дорхноо нэг хээнцэр салбадай дэргэд нь хүрээд ирнэ. мань хүүхэн бушуухан зайлна, нөгөөдөх нь салах язнгүй бол дэлгүүр рүү орчихно.

Тэрээр үнэртэй ус, сүрчиг мэтийн аахар шаахир юм авна. Нэг удаа унтлагын гоё цамц, бас бус дотуур хувцас үзсэн, дараа нь гэрийн шаахай, гал тогоонд өмсөх хормогч авсан. Худалдаж авсан юмаа Шарльд үзүүлэхэд цаадах нь дандаа сайшаана. Өөрийг нь хоргоохыг завддаг эрээ цээргүй харчуулын тухай эгдүүцэн ярихад Шарль инээд алдана,

-Хонгор минь, чи дэлгүүрийн цонхон дээр битгий зогсож бай, тэнд чинь жуулчид юм уу,

ядмаг авгайчуул л хямд юм харж зогсдог юм гэж тайлбарлав.

Харин энэ яриа тун санамсаргүй төгсчээ. Шарль түүнээс өршөөл гуйсан аж.

-Би чамайг дутмаг анхаарч байсан бололтой. Цонхны үзүүлэнг харж яваа бол чи өөртөө юм хум авмаар санагддаг байх нь. Нээрэн, хоюулаа дэлгүүр явна аа. Чи хаврын бэлтгэлээ хийх хэрэгтэй.

-Өө, амжина даа гэж Вика даруутаснаа тэгсхийгээд тэсэлгүй, -Чи намайг хааш нь дагуулж очмоор байна, “Каролина”-д уу? гэж асуув.

Цаадах нь гайхсхийн,

-Өө, чи “Каролина”-г мэддэг юм уу? гэв.

-Энэ дэлгүүрийн тухай би Москвад байхдаа дуулсан. Парисаас элдэв хээнцэр новш очвол “Энэ чинь “Каролина”-гийнх” гэгцгээдэг байхгүй юү.

-Тэгвэл тийшээ чинь л очицгооё. Би дэлгүүрийн эзэнтэй утсаар яриад тохирчихно, тэгээд хоюулаа чамд хос даашинз, хослол энэ тэр захиалчихья, өөр бас юу хэрэгтэйгээ чи харна биз.

Сургуулийн хичээлийн эрхлэгч утасдсанаас гадна районы намын хорооноос Нинаг сураглаж, хэн болохыг хэлээгүй хэдэн хүн Нина Ивановна Ивановаг асуужээ. Варяг ажил дээрээ байхад өдрийн цагаар ийнхүү утасдсаныг хөршүүд нь түүнд хэлэхийн хамт өөрсдөө, “Нээрэн, Нина хаачсан юм бэ?” гэж гайхширцгааж. Варя хайхрамжгүй дал мөрөө хавчиж,

-Би яаж мэдэх вэ? Тэр чинь надад тайлагнадаг хүн биш. Нэг тийшээ, аль нэг семинарт явчихаа биз гэнэ.

Варя одоо ажлаасаа сургууль руугаа явах замд өдөр болгон Төв шуудангаар шүргэх болжээ. Эхлээд Костромоос “Бүх юм ёсоор, үнсье” гэсэн цахилгаан иржээ. Дараа нь яг тийм, бүгд гарын үсэггүй цахилгаан Курган, Новосибирск, Красноярскаас ирэв. Тэгээд эцэст нь Хабаровскоос “Бүх юм ёсоор, Макс бид хоёр үнсье” гэсэн цахилгаан ирлээ. Варя тэр дор нь Максимд хариу явуулав: “Би сайн, ажил сургуульдаа явж байна, та нарыг үнсье, Варя”. түүнийг хаанаас ч таталж чангаагагүй, бүх юм хуучин хэвийн мэнд сайн байгааг цаадуул нь энэ цахилгаанаас ойлгох ёстой.

Хэсэг хугацааны дараа Нинаг мартацгаажээ. Утасдаж сураглах, асууж шалгаах хүнгүй болж.

Ингээд хэрэг бүтэх нь тэр, Максын хажууд Нинад аюул байхгүй. Тэндээс түүнийг хэн ч олохгүй, тэнд засгийн тулгуур, Сталины тулгуур болсон арми, манай яруу алдарт нисэгчид, танкчид, их буучид байгаа. Өөр хэн билээ? Өө, тийм манай яруу алдарт морьт хорооныхон байгаа.

Варя Улаан Армийн ордонд болсон төгсөгчдийн үдэшлэгийг нэхэн саналаа. Гурван жилийн өмнө тэр бүхэн хичнээн тэнгэрлэг сайхан санагдаж байлаа даа. Одоо бүх юм өөр болжээ. Одоо цэргийн дүрэмт хувцастай до яамныхан л гудамжаар холхиж байна. Юрка Шарокийг тийм хувцастай явахыг харснаас хойш Варя энэ хувцаснаас хүртэл жигшдэг болжээ. Гэхдээ цэргийнхнийг бага багаар нь шоронд хийж эхэлсэн нь үнэн. Тэдний байшинд иргэний дайнд улаантны талд оролцсон, хаант засгийн нэг ахимаг генерал байсан. Цэргийн академийн профессор, буурал хуузтай, хавчдаг шилтэй, толиотой сайхан генерал. түүнийг шоронд хийчихсэн! Бас шүүх хурлаар Мураловыг шүүж байна. Гэтэл Варя баярын сонин дээр, “Парад командлахыг надад тушаасан болно. Муралов” гэж бичсэн байдгийг саналгүй яахав. Тэгсэн чинь, одооны бичиж байгаагаар бол герман-японы тагнуул юм байж. Инээдэм! Харин Максим Костин бол... Түүн шиг зүтгэдэг хүнд юу ч тохиохгүй. Хээ шаагүй ч элгэмсэг хөвүүн. Нина түүний ард хадан хананы цаана байгаагаар адил байх болно. түүнийг Алс Дорнодоос хайна гэж хэний толгойд орох вэ дээ?!

Варя бүх юмаа ганц Софья Александровнад л ярьжээ. Тэр хоёрын хооронд нууц юм гэж байх биш.

-Тэр нь зөв хэмээн Софья Александровна Нинагийн явсныг дэмжив. -Тэдний сургуулиас чинь захирлаас гадна нэг багш, бас аравдугаар ангийн хэдэн хүүхдийг шоронд хийсэн гэлцэх юм байна шүү дээ. Манай байшингийн Парамонов гэж хүү орчихож. Яагаав, тавдугаар орцны, мэдэх үү? Сталины тэр нэг заяагүй баримлаас болж тэглээ гэж үү?

-Та юу гэж бодоов, тэр байтугай юмны төлөө хийнэ шүү дээ!

-Нинад ч, мэдээж, хэцүү байгаа. Яаж итгэж явлаа даа гэж авгай өгүүлэв.

Өрөвдсөндөө тэгж өгүүлж. Сашагийнх нь хувь заяаг найзууд нь тоохгүй байгаад эгдүүцдэг, Саша л ганцаараа зовж, бусад нь цөмөөрөө сайхан байгаа мэт санагдан гутардаг байсан цаг нэгэнт өнгөрчээ. Одоо их, багагүй бүгд зовж байна, цаг хугацаа бүгдийг дээр дооргүй адилхан болгожээ. Марк буудуулсан, Иван Григорьевич шоронд орсон, Нина баривчлагдалгүй амь зулбан гарсан. Гэтэл Саша, харин ч, буцаж ирэх нь. Буцаж ирэх үү?

Софья Александровна хоног тоолон суугаа билээ. Сашаг яг хугацаанд нь суллаж, бичиг баримтыг нь цагт нь өгөх юм бол хоёрдугаар сарын 10-дын үеэр төмөр замтай газар ирнэ, тэгээд цахилгаан өгнө. Гэхдээ бичиг баримт нь хожуу очиж болно, ой тайгаар өвлийн цагт төмөр зам хүрэх амаргүй, тэгэхээр наад зах нь хоёр долоо хоног нэмэх хэрэгтэй. Тэгэхээр хорин таван гэхэд цахилгаан ирэхгүй бол ямар нэг юм болсон байж таарна. Одоохондоо бол тэвчээртэй хүлээх хэрэгтэй.

Энэ тооцоогоо Софья Александровна Варяд ярьжээ. Варя ч бас тооцож байгаа, мань хүн дэргэд нь хуруу даран тоолж үзүүлэхэд арай цөөн хоног гараад байв. Саша Москвад сууж болохгүйг Варя ээжийнх нь адил мэднэ. Тэр ч яахав, хаа суух газар руу нь яваад очно. Хэрэгцээ гарвал, хоюулаа төвхнөх хот руугаа эндэх байраа солих арга бодно, тэнд нь ажилд орж байгаад, сургуулиа эчнээ болгочихно. Аль нэг бяцхан хотод аж төрөх хэрэг болох байх. Хот жижиг байх тусмаа сайн, аюул осол багатай. Уул нь тосгонд бол бүр зүгээрсэн, гэвч одоо хаа сайгүй хамтрал болчихсон учраас тосгоны тухай бодохын ч хэрэггүй. Козловт очиж болох юм, одоо Мичуринск гэдэг болсон, Нина тэр хоёр тийшээ хамаатан эгчийндээ нэг удаа очиж байсан билээ. Саша тэр хоёрыг таних хүн тэнд нэг ч байхгүй. Ажил хийцгээнэ. Эргэн тойрон сайхан цэцэгт нуга байгаа, түүгээр хоюулаа хөтлөлцөн зугаална. Варя ирээдүйгээ иймэрхүү янзаар төсөөлнө. Сашаг суллахгүй тухай Тэрээр бодохыг хүсдэггүй, боддог ч үгүй билээ. Гагцхүү сууж болох газраа л сонгочихвол бол оо, мань хүүхэн тэр даруй тийшээ тавьж хүрнэ.

Энэ бүхнээ аль хэдийн тууштай шийдсэн, ямар нэг эргэлзээ байхгүй, Саша ч ийм шийдтэй байгаа гэдэгт Варя бат итгэж байв. Тэр хоёр энэ тухай бичилцэж тохиролцоогүй, хүмүүсийн захиаг, ялангуяа цөллөгнийхний захидлыг хянадаг, уншдаг юм чинь яая гэхэв. Гэхдээ Сашагийн захидал болгоноос, өөрт нь зориулсан мөр болгоноос тэр хоёр бодол санаа нэг байгаа, уулзан золгох мөчийг адилхан хүлээж буйг Варя мэдэрсээр ирсэн билээ.

Чухамдаа бүх юм “Арбатын нүхний” тэр нэгэн үдэшлэгээс эхэлсэн, дараа нь шоронгийн хана дагасан урт оочер, захидал, илгээмж, Сашагийн тухай ээжтэй нь, Михаил Юрьевичтэй ярьж хөөрсөн зүйлс энэ тэрээс түүний Сашаг хайрлах сэтгэлийн зам цэгцрэн шулуудсан болой. Энэ зам азтай өлзийт учралаар отголон тэр хоёр золгож, түүнээс хойш тэр хоёр хэзээ ч хагацах ёсгүй. Костя гэж нэг хүн байсан нь үнэн, Тэрээр түүний богинохон майга хөл, үсэрхэг нурууг сэжиглэн дурсав. Энэ бол тохиолдлын зүйл, энэ бол алдаа. Костятай толгой холбосон нь нэг л юман дээр тус болсон, Варя эдүгээ ресторан, бүжиг, харчуул энэ тэрийн алийг ч сонирхохоо больжээ. Михаил Юрьевичтэй ярилцан тэднийд цаг нөгцөөх, эсвэл Софья Александровнатай элдвийг бурах нь хавьгүй таатай.

Тэр хоёр Сашаг байнга дурсавч түүнд сэтгэлтэйгээ Варя ээжид нь тухайлан эс ярина. Ер нь энэ бол мэдээж зүйл. Софья Александровна бүгдийг харж, бүгдийг ойлгож байгаа нь лав. Ирээдүйн тухай төлөвлөгөөгөө түүнд хэлнэ гэдэг бол эмзэг шархыг нь сэдрээнэ гэсэн үг. Энэ зовлон нүүрлэсэн цөвүүн цагт аз жаргалын тухай ярих нь зохисгүй, ер нь ч аз жаргал алга, амьдрал байна, амьдралын төлөө тэмцэл байна, цаашдаа ч амьдралын төлөө тэмцэл л байх нь.

Софья Александровна Варяг ажил дээрээ байхад гэнэт утасджээ. Хоолой нь чичирч буй нь илт.

-Орой манайхаар ороорой.

Варя тэр даруй харайлгаж хүрчээ.

-Юу болоов?

Софья Александровна Сашагийн Красноярскаас явуулсан цахилгааныг түүн рүү сарвайснаа уйлчихав.

“Замд явж байна, утасдана”.

Варя Софья Александровнаг тэврэн авахад, авгай түүний өвөр рүү наалдлаа.

-Софья Александровна, тайвшир, ийм азтай мэдээ байхад та уйлж яаж болохов! Саша ирж явна, ойлгож байгаа биз дээ, ирж явна.

Гэвч Софья Александровна мэгшээд юу ч хэлж чаддаггүй, давжаа бие нь л мэгшихийн хэмээр овгонон байна. Энэ хэдэн жилд адлуулсан бие сэтгэл нь тавирсандаа Сашагийн баригдсан цагаас хойш уйлж үзээгүйгээрээ уйлж байгаа нь энэ.

Варя Софья Александровнаг буйдан дээр суулгаад, хоёр гарыг нь барьж илбэн аргадав. Өөрийнх нь нүдэнд нулимс цийлэгнэж байгаа ч, сормуусны будгаа нялахаас болгоомжлон нулимсаа арчсангүй.

-Софья Александровна, та бид хоёр баярлаад бүжиглэх ёстой атал уйлж байх юм! Шулуухан үнэнээ ярьцгаая. Сашаг суллана гэж бид хоёр зуун хувь итгэж байсан бил үү? Үгүй шүү дээ! Гэтэл мань хүн бүр Красноярск хүрээд ирчихсэн байна! Танд нэг газрын зураг байсан, түүнийгээ өгөөч, Красноярск хаа байдгийг харъя!

Варягийн өчнөөн төчнөөн бодсон нөгөө ирээдүй чинь одоо бодит дүрсээ олоод ирлээ. Саша суллагдчихаж! Хаана аж төрөхийгөө тэр өөрөө шийднэ, мань хүн түүн рүү яваад очно.

-Софья Александровна, аль вэ, зургаа өг л дөө, Саша хаагуур, ямар хотуудаар дайрч явж байгааг хоюулаа харъя.

Софья Александровна тавиур дээрээс зургаа авч ширээн дээр

дэлгэв. Тэр хоёр Красноярскийг оллоо. Варя Красноярскаас Ново-сибирск хүртэл хуруугаараа зурж, цааш нь Омск, Свердловскийг хүргэв.

-Наанаа зогс гэж Софья Александровна хэлэв. -Саша хэрвээ Красноярскт шууд галт тэргэнд суусан бол биднийг тосог гэж түүнийхээ дугаар энэ тэрийг мэдэгдэх ёстой. Тэгэхээр дамжиж

явж байх нь. Тийм бол Свердловскоос нэг бол Казаниар дайрч явна, нэг бол Кировоор дайрч явна, тэгдэг гэж би олж мэдсэн юм. Тийм учраас аль буудал дээр тосох нь ойлгомжгүй байна, Ярославлийнх уу, Казанийх уу?

-Тэр чинь “утасдана” гэж бичиж шүү дээ.

-Өө, нээрэн тийм, тэгвэл, галт тэрэгнийхээ дугаарыг хэлье гэхгүй байгаа юм байна.

Тэгээд бодолхийлснээ,

-түүнийг ирж яваа гэж хэнд ч хэлэхийн хэрэггүй гэж нэмж өгүүлэв.

Варя гайхаж хоцров.

-Юуг нь нууцлах юм бэ? Ямар цөллөгнөөс оргосон биш, хүн суллагдаад ирж байхад.

-Саша Москвагаар дайрч гарах ч эрх байхгүй. Тийм учраас л “утасдана” гэж тодорхойгүй бичиж. Бүх юмыг хянаж, юм болгоныг шалгаж байгаа шүү дээ. Замаасаа ч утасдаж магадгүй, эсвэл очих газраасаа ч утасдаж мэднэ. хэний ч санаанд орохгүй. Гэтэл надад, яагаад ч юм, Москвагаас утасдах юм шиг санагдаад байх юм.

-Та эзгүй байвал яана аа? гэж Варя болгоомжлов.

-Би гэртээ байна. Яг маргаашаас амралтаа авна. Би ноднингийнхоо амралтыг ч гүйцэд эдлээгүй. Тэгээд утасны хавьд суугаад байдаг хэрэг.

-Сашаг утасдвал та тэр дор нь надад хэлээрэй, би ч бас галт тэрэгний буудал руу очно гэж Варя хэлэв.

-Чамд заавал утасдана. Энд, мэдээж, ганц өдөр ч гэсэн саатаж болохгүй. Галя дор нь алтан хошуу өргөчихнө.

Варягийн зүрх оволзоод явчихав.

-Манайд болно шүү дээ. Би одоо ганцаараа юм чинь. Нина байхгүй.

-Варенька минь, танай хөршүүд Сашаг танина. Байшингийн тэрүүгээр явах болно, бас хэн нэг нь харчихна. Харин манай дүү Верагийн бууж болох юм болов уу, тэднийх жижигхэн хоёр өрөөтэй, тусдаа байртай. Гэтэл тэд дөрвүүлээ, гэхдээ бас зуслангийн байр бий, одоо ч цэв хүйтэн, эзгүй түгжээтэй байгаа, гал түлээд дулаацуулчихаж болно. Гэхдээ Саша юу гэх нь вэ, харж байж больё. Шууд яваад өгөхгүй гэхийн ч газаргүй, тэгвэл замын хүнс хэрэг болно. Варечка, чи авчихгүй юу? Би гэрээсээ гармааргүй байна,

чамд мөнгө өгье.

-Надад мөнгө бий гэж Варя хэлэв.

-Би тэртэй тэргүй маргааш өглөө хадгаламжийн касс руу очно, тэндээс мөнгөө аваад, ажлаараа орж амралтынхаа тушаал энэ тэрийг гаргуулна.

Софья Александровна авдран дахь юмаа онгичиж эхлэв.

-Юмыг яаж мэдэхэв, Сашад юухан хээхэн бэлтгэе, ноос удаан тэсдэггүй юм чинь оймс нь урагдчихсан ч байж мэднэ.

-Софья Александровна, та амжина. Эрх чөлөөтэй болоод анхныхаа цахилгааныг ирүүлсэн байна. Ийм сайхан үйл явдал болж байхад та оймс моймс гээд л. Тэр цахилгаанаа надад бариулж ч үзүүлээгүй байгаа шүү дээ.

Софья Александровна инээв.

-Нээрэн тийм, май, унш.

Варя хэдийгээр цээжээр мэдэж байгаа ч, өөрийнхөө нүдээр гүйлгэж харахад сэтгэлд баяр хөөр бялхах шиг. “Замд явж байна, утасдана”.

-хүнсний зүйл юу авахыг та жагсаагаад биччихээрэй гэж Варя гарахдаа хэлэв.

Хүлээлгийн зовлонтой өдрүүд эхлэв. Софья Александровна хоёр долоо хоногийн амралт авч, гэртээ суудаг боллоо. Хонгилын утас тэдний хаалганы хажууханд байдгийг ч хэлэх үү, дуугарангуут нь хамгаас түрүүнд очиж авна. Сашагаа яг тэр үеэр утасдах байх гэж эмээгээд өөрөө утсаар хүнтэй удаан ярихгүй, хөрш хүүхэн Галя нэг ярихаараа бураад салахгүй, манай хүн дэмий л дотроо бухимдана.

Гэтэл нэг өдөр өнгөрлөө, хоёрдахь, гуравдахь өдөр өнгөрлөө, Саша утасддаггүй.

Варя орой болгон ирэхдээ Софья Александровнад идэх юм ав-чирч өгнө. Сашад зориулсан хүнсний зүйлийг бас авчирлаа. Софья Александровна гахайн өөх, утсан хиамаа муудахаас сэргийлэн цонхныхоо завсар хийж ётонгоо сав суулганы шүүгээнд нуув.

Галт тэрэг Моква руу ойртож явна. Зорчигчид юм хумаа эмхэлчихэж. Үйлчлэгч хогоо шүүрдэх гэж өөрөө хүн амьтанд саад болоод байгаа хэрнээ тэднийг харааж зүхэж байна.

Саша цонхны шил рүү хэд амьсгалаад гараараа арчсанд, нэлийсэн цасан цагаан тал, ов тов цөөн модны төгөл, зуслангийн зогсоолын хоосон тавцангууд энэ тэр нүднээ жирэлзэн тодорлоо. Москва орчмын хүүхэд ахуйгаас танил дасал болж сэтгэл, дэнслүүлсэн нутгийн бараа.

Москвад түүнийг юу хүлээж байгаа билээ?

мань хүн утсаар ярихдаа ямар нэг онилгүй юм хэлчихвэл ээж нь тэсэхгүй. Аягүй бол, нэрийг нь хэлээд үйлчихна, тэгвэл хөршүүд нь сонсчихно, гэрт нь гаднын хүн байхыг хэн байг гэхэв, үгүй бол, түүнийг тэнд хэдийн о т о ж байж ч мэднэ. За, тиймгүй байлаа гэж санахад, ээж нь “хүрээд ир” гэж хэллээ гэхэд мань хүн байрныхаа дотуур талбайгаар яаж өнгөрч, шатаар яаж өгсөх вэ? Нэг л хүн харвал бүгдээрээ мэдлээ гэсэн үг.

Варя руу утасдах уу, мань хүн ээжид нь утасдах юм уу, биеэрээ очоод хэл өгнө биз. Гэтэл тэнд Нина байгаа. Нина, мэдээж, хов хүргэх гэж харайлгахгүй. Тэглээ ч гэсэн... Ер нь Варя ээжид юу гэж хэлэх болж байна? Саша Москвад ирчихээд, буудал дээр байна, тантай яаж уулзахаа мэдэхгүй байна гэх үү? Үгүй ээ, энэ дэмий юм байна.

Вера эгч рүү утасдах уу? Тэднийхээр түр очих уу? Гэтэл нөхөр нь юу гэх бол, хоёр хүүхэд нь юу гэх бол, ер нь Вера эгч нь ч өөрөө юу гэх юм бол? Цаг өөр болж, хүмүүс ч өөрчлөгдсөн, Тэрээр хэнийд ч бууж чадахгүй, хэнийхээр ч шүргэж болохгүй. Паспортын дэглэм зөрчвөл зөвхөн өөрөө хариуцлага хүлээгээд зогсохгүй, орсон айлынхан бас хүлээнэ. Тэдэнд Панкратов гэгч Москвад байсныг яагаад мэдээлээгүй вэ? гэсэн асуулт тулгана. Тэр ч байтугай, утасдаж ч болохгүй, бас л яагаад илтгээгүй вэ? гэнэ. Нуусан, дарсан, паспортын дэглэм зөрчихөд тусласан хэрэг болчихно!

хэнийд ч очихгүй, хэнд ч утасдахгүй, яршиг чи минь. Москвагаас шууд, аль болохоор түргэн явах минь. Галт тэрэгнээс галт тэргэнд шилжээд л. Хаашаа явах вэ? Калинин руу. Тусгай дэглэмгүй, Моск-вад ойрхон хот, бас таних хүн бий, Михаил Михайлович Масловын авгай, Мозговад очиж байсан Ольга Степановна. Яльгүй ч гэсэн, ямар ч атугай, нэг сэжүүр. Хаяг нь бий, Михаил Михайловичид юу тохиосныг мань хүн авгайд нь мэдээлж захиа бичсэн, ээ бас, гуниг-тай захиа, гэвч үүргээ биелүүлэх ёстой байсан учраас явуулахаас яахав. Одоо бол аятайхан шалтаг. Захиа авсан уу, нөхөр тань яасан бэ? гээд очиход. Өрөө хөлслөх юм уу, айлын зайнд толгой хоргодох газар олоход дэм үзүүлж магадгүй. Тэгээд маргааш Калининаас ээж рүүгээ утасдана.

Цорын ганц зөв хувилбар! Өөрөө ч эрсдэхгүй, бусдыг ч хөөдөхгүй, аюул осолгүй, хууль ёсны хувилбар.

Калинин гэх бас нэг учир бий. Саша Мозговад байхдаа, гучин таван онд бил үү дээ, Москва мужийг хувааж, Калинин гэж муж байгуулаад, мужийн намын хорооны нэгдүгээр нарийн

бичгийн даргаар М.Е.Михайлов сонгогдсон гэж сониноос уншсан билээ. Михайлов эсвэл өөрөө тэдний байшинд суудаг, эсвэл тэнд суудаг эцэг эх дээрээ ирдэг байсан байх, ямар ч атугай, Саша бүүр түүрхэн санадаг юм. Санадагийн учир гэвэл түүний дүү Мотятай үерхдэг байсан билээ. түүнийг намын том дарга гэж Мотягаас л дуулсан хэрэг.

Саша шатар тоглох гэж Мотя дээр байн байн ирнэ. Мотя бодоо хассан хэрнээ л мань хүнийг хожчихно. Тэгж байхдаа л Мотягийн ах Михаил Ефремович Михайловичийг харсан билээ. Тэр үед Саша намын том дарга нарыг их хүндэтгэдэг байсан болохоор Мотягийн ахыг ч бишрэн хардаг байж. Энэ явдал арван хоёр, гурван жилийн өмнө тохиосон юм чинь, Михайлов дүүтэй нь шатар тоглож байсан бандийг тогтоож авсан нь юу л бол, ер нь түүнийг туслана гэж найдвал инээдэмтэй хэрэг болно, мань хүн мужийн намын хорооны дарга дээр хэзээ ч орж чадахгүй. Тэглээ ч гэсэн, эрхбиш танил овог, нэртэй байх юм даа. Калинин мужийн удирдлага өөрийнх нь найзын ах, Сашагийн хүүхэд ахуйн дурсамжтай ямар нэгэн учигаар холбоотой хүн. Гэтэл Мотя тэнд байж байх ч юм бил үү?

Бол оо. Зүйтэй. Шийдлээ! Талбайн цаад талд Ленинградын буудал байгаа, аз таараад, Калинин руу одоохон галт тэрэг явах гэж байж ч мэднэ.

Саша ирсэн, тоссон олны дундуур шахцалдсаар Комсомолын талбай дээр гарч ирлээ.

Москва, ээ, чөтгөр чамайг, Москва! мань хүн Москвад ирчихэж. Трамвай зогсоол руу ирэхийг хараад зүрх нь дэлсээд явчихлаа: 4 дүгээр чиглэлийн трамвайг төрөлхийн унаа ч гэж хэлж болно. Тэрээр зөвхөн энэ “дөрвөөр” л гурван буудлын талбай дээр ирдэг сэн. Ачтайгаа яваа юм уу, нэг хүүхэдтэй эмгэн арын хаалгаар бууж байна, уул нь тэгж болохгүй шүү дээ, элдэв хөндлөнгийн дарамтгүй, айх ичих, санаа зовох юмгүй, аз жаргалтай, мөрөөрөө аж төрж яваа улс л ийм байдаг байх. Машин, трамвайгаар яваад л... Нээрэн, машины тоо нэмэгдчихэж. Бусад нь яг хуучнаараа. Нөгөө л мухлаг, лангуунууд, нөгөө л Казанийн буудлын орой дээрх зурхайн цаг. Саша энэ талбай дээр хичнээн удаа ирсэн билээ, пионерийн зуслан энэ тэр рүү энэ гурван буудлаас хичнээн удаа явсан билээ...

Энүүхэн булангийн цаана гутал тослогчийн бүхээг байгаа, сахалтай ассир өвгөн бий. Яг даа, бүхээг ч байж байна, өвгөн ч мухар сандал дээрээ сууж байна, амьд мэнд байна! Саша түүн рүү инээмсэглэн харсанд өвгөн ойлголгүй, үүдээ нээсхийж,

-Тослуулах уу? гэв.

-Дараа больё.

Гэтэл талбай дээр гараад ирэнгүүт бөөн айдас дахиад эзэмдээд ирлээ: Москвад орж ирэх эрхгүй байтал толгойдоо дэмий булуу хурааж явна. Нөгөө Тайшетийнх шиг энд бас эргүүл хийдэг, бичиг баримт шалгадаг байвал яана? Хөөе, тэр чемодантай иргэн, аль вэ, паспортоо гэвэл? Тэгвэл дахиад л бөөн юм эхлэнэ. Ямар үндэстэй Москвад ирэв? Дайрч явна уу? Тэгвэл дамжих тасалбар байх ёстой, гэтэл бидэнд та юу үзүүлж байна? Дахиад л хууль зөрчиж байна, дахиад л хуучнаа сэргээж байна, биднийг дагаад яв!

Саша бодлогоширч яваад, нэг цэргийн хүнийг санаандгүй мөргөчихсөнд, цаадах нь чанга гэгч

харааж, тэр дорхноо хэдэн хүн зогтусч, юу юугүй цагдаа дуудах нь уу гэлтэй болоод явчихав. Яльгүй юмнаас болж тамаа цайж мэднэ. Тэрээр уучлалт гуйчихаад, алхаагаа түргэсгэн, бараг гүйх шахан талбайг хөндлөн гарч, Ленинградын галт тэрэгний буудал руу орлоо. Ингэж зовж, доромжлуулж явах ч гэж дээ! Амьсгаагаа жаахан дараад, хэрэгтэй цонхоо олж, оочер энэ тэр гэлгүй тасалбар худалдаж авав. Калинин руу галт тэрэг гурван цагийн дараа явна. Хоёр тасалбартай болж сая нэг санаа амрав. Нэг нь Свердловскоос Москвад ирсэн тасалбар, нөгөө нь Москвагаас Калинин явах. мань хүн нэг галт тэрэгнээс нөгөөд шилжин суух гэж буйг тасалбар нь нотлоно, ийнхүү шилжин суух учраас хууль зөрчсөн юм алга.

Дорхноо тайвширсандаа болоод, өөртөө дургүй хүрч урам нь хугарав. Москва руу ойртохоос эхлээд л айсан, талбай хөндлөн гарахдаа ч айсан, тасалбарын цонх руу очихдоо ч айсан. Одоо зөвхөн ийм байдлаар аж төрнө гэж үү? Булан тохой болгон дээр нуугдаж, хараа мөргөлдөх тоолонд хэрдхийж, баруун солгойгүй хулганаж, зөрөх хүн болгоноос эмээж болгоомжилж явах хэрэг үү?

Үгүй, ямар үхсэн биш. Ийм хийморьгүй байдлаас гарах хэрэгтэй, эс тэгвэл ёстой балрана, хог новш болж хувирна. Биеэ өөд нь татах хэрэгтэй. Тэднүүс чамайг айдсаар няцлах гэж байна. Гайгүй байлгүй! Яагаад гэр рүүгээ утасдах эрхгүй гэж? хэн хориглож чадах юм бэ?

Саша буцаж гараад, автомат утасны бүхээгт орж, зоосоо хоног руу нь хийлээ.

Утас хэд зайтай дуугарснаа ээжийнх нь дуу сонсдох нь тэр:

-Би таныг сонсож байна.

Ээжийнхээ дууг сонсоод зүрх нь бас зогсчих шиг болов. Ээж нь энд, энүүхэн хажууд нь байна.

-Ээж ээ, тайван байгаарай хэмээн Саша эхлэв. -Би Саша байна. Би болж бүтэж явна. Одоо Ленинградын буудал дээр байна, Калинин хот руу явна, маргааш тэндээс утасдана.

-Бие чинь сайн уу? гэж ээж нь тайван асуув. Утасдсанд ч гайхсан шинж алга, гэрээрээ орохгүй байгаад ч гайхсан шинж алга.

-Сайн чиш!

-Галт тэрэг чинь хэзээ явах юм бэ?

Саша ээжийнхээ тэсвэр тэвчээрийг үнэхээр гайхав.

-Гурван цагийн дараа.

-Би одоо очлоо.

-Ээж ээ, юу гэсэн үг вэ, яах нь вэ?

-Чи аль цонхон дээр оочерлож байна?

-Би тасалбараа авчихсан.

-Буудлын орох хаалган дээр хүлээж байгаарай. Би ингээд гарлаа.

-Ээж ээ!

Харилцуур тасран дуу нь гонгиноод явчихлаа.

Саша буудал руу буцаж ороод, орох хаалганаас холгүй чемодан дээрээ суузнав.

Дөрөвдүгээр трамвай наашаа шууд ирдэг ч ээж нь зогсоол хүрнэ, трамвай хүлээнэ, тэгээд наашлана, тэгсээр байтал наад зах нь нэг цаг болно.

Хүлээхээс өөр яахав.

Саша буудлын байшингаас орж гаран, цаг нөгцөөх зуур ээжийгээ бодов.

Гэрээрээ орж чадахгүй байгааг ээж нь яг ойлгож байна, яасан сайхан тэвчээр вэ, өөрийнх нь урмыг хугалахгүй гэсэндээ тэр тухай дурсах ч үгүй байна. Ямар тайван ярьж байна аа.

Утасдахыг нь хүлээж байж, Красноярскаас явуулсан цахилгааныг авсан өдрөөсөө хойш л хүлээж байж, хоёр долоо хоног хүлээсэн хэрэг, мань хүн “утасдана” гээд биччихсэн юм чинь утас чагнаад, гэрээсээ ч гардаггүй, шөнө ч унтдаггүй байсан байх.

Ээж нь гэнэтхэн хүрээд ирлээ. Яаж ойртож ирснийг нь Саша анзаарсангүй. Нэг мэдэхэд л хүн шүргэх шиг болсон чинь ээж нь түүн рүү шигдэн уйлж байв. Саша ээжийгээ тэврэн толгой дээр нь үнслээ. Саарал алчуур зангидчихаж. Хуучин далайн хар мууран малгайгаа далиу духдуулсхийн өмсөж, түүний цаанаас буурал үс нь сайхан сэмбийж байдаг сан. Тэр малгай элэгдсэн бололтой, энэ хээгүй саарал алчуур ээжийнх нь дутуу гуцуу аж төрж байгааг яах аргагүй илтгэж байна.

Тэгснээ ээж нь толгойгоо өргөж, гуниг хурсан нүдээр түүнийг ханаж ядан харснаа, уруул нь дахин өмгөнөж, хүү рүүгээ дахин шигдлээ.

Ээжийгээ мөрөөр нь тэврэн, буудлын байшин руу орж, урт сандал дээр зайчлан суулгаад, өөрөө хажууд нь чемодан дээрээ суув.

Ээж нь түүнийг үг дуугүй, мэлрэн харсаар байна.

Саша инээмсэглэн,

-Ээж ээ, сайн байна уу? Ам нээгээч дээ! гэв.

Ээж нь түүн рүү чимээгүй мэлэрсэн хэвээр.

мань хүн сахал нь ширэлдсэн хацраа нэгэнтээ илж,

-Галт тэргэнд сахал хусах боломжгүй, өртөөний үсчингийн газрын бохирыг хэлээд яахав

ХЭМЭЭН ИНЭЭВХИЙЛЭВ.

Тэр жил Бутыркийн шоронгоос ачигдах гэж байхдаа ээждээ яг ийм бил үү, эсвэл иймэрхүү бил үү, үг хэлж байж билээ. Тэр л үгээрээ одоо ээжтэйгээ золгож байна.

-Калининд очингуут, өнөөдөртөө багтааж өөрийгөө тордож авна аа.

Ээж нь,

-Одоо хэдэн жил хар дансанд явах вэ? гэж асуув.

-Хар дансанд хугацаа байхгүй.

Цүнхээ нээж, нэг дугтуй гаргаж ирэв:

-Энэ чамд өгөх мөнгө, таван зуун рубль.

-Тийм их үү?! Талыг нь өөртөө үлдээ, за юу.

-Үгүй чиш, тийм юм бүү ярь, Марк чамд шилжүүлж байсан мөнгө, хадгаламжинд байгаа, цаана нь бүтэн хагас мянга үлдсэн, чамд хэрэг болохын цагт дахиад авна.

Тэрээр Саша руу харснаа,

-Саша, би чамд нэг юм хэлэх ёстой... гээд санаа алдан, түүн рүү хүчлэн харсан чигээрээ, - Маркийг буудаад хороочихсон гэж өгүүлэв.

Саша хоёр нүд нь орой дээрээ гарч ээж рүүгээ харав. Маркийг буудан алсаан?! Марк байхгүй болчихоо юу?!

-Чамд энэ тухай бичээд яахав гэж бодсон юм. түүнийг наймдугаар сард баривчилсан. Кемеровод шүүн тасласан...

Саша дуугарсангүй. Ээж нь түүнээс хараа салгалгүй үргэлж-лүүлэв:

-Иван Григорьевич Будягин баривчлагдсан, Ленаг хүүхэдтэй нь, Владлены хамт Зөвлөлүүдийн тавдугаар байрнаас хөөж, нийтийн байранд оруулсан.

Ямар аймаар мэдээ вэ! Саша хэдхэн хоногийн өмнө Иван Григорьевичийг дурсан санаж байсан, гэтэл Тэрээр аль хэдийнэ шоронд сууж байсан болох нь... Хөөрхий муу Лена, хөөрхий муу Владлен!

-Лена хүнтэй суусан уу?

-Үгүй ээ, суугаагүй. Хүүхдийнх нь эцэг Шарок, гэхдээ тэд нар нэг дор амьдардаггүй, тэр ч бүү хэл, уулздаг ч үгүй гэсэн байх аа.

Софья Александровна хэсэг дуугүй болсноо,

-Калинин руу чи хэнийд очих гэж байгаа юм бэ? гэж асуув.

-Миний нэг танилын авгай тэнд байдаг юм.

-Би бол чамд хоёр хаяг бэлтгэсэн юм. Нэг нь Рязаньд, Михаил Юрьевичийн дүү, тэнд мужийн төлөвлөгөөний газар ажилладаг, Евгений Юрьевич, Москвад бишгүй ирдэг байсан, чи түүнийг санах л ёстой, Михаил Юрьевич түүнд хэлчихсэн байгаа, болох, чадах юмаараа тэр туслана.

Хоёрдахь хаяг нь Уфа, тэнд Верагийн нөхрийн дүү байдаг юм. Вера түүнд бас биччихсэн байгаа. Рязань бол уул нь ойрхон, зүгээр юм, гэхдээ бодно биз. Битгий л цөхөрч гутраарай, энэ их чухал шүү, хамаг хэцүү чинь ард хоцорсон. Чамайг төвхнөчихтэй чинь зэрэг би ирж очиж байх болно.

Ээж нь Михаил Юрьевичтэй хамт сайхан бодож боловсруулаад, бэлтгэчихсэн байна. Мэдээжийн хэрэг, Варя бас оролцсон байж таарна. Ямар гэнэн, ямар ялдам хүмүүс вэ. Ягаан мөрдөстэй нэг муу тоть сэжигтэй харцаар ганц харсан байхад л эд нарын төлөвлөгөө тэр аяараа нурна шүү дээ.

Хэдий тэгэвч ар талд чинь үнэнч хүмүүс байна гэдэг бол үнэхээр аз жаргал юм.

-Чи нөгөө хөрөнгийн бүртгэлийн газраа л ажиллаж байгаа юу?

-Тийм. Одоо амралтаа авчихсан байгаа.

түүний утасдахыг хүлээн, утсаа чагнаж суух гэж амралтаа авсаныг Саша ойлгов.

Ээж нь том цүнхнээсээ боодолтой юм гаргаж ирэв:

-Энд замын хүнсэнд хэрэглэх юухан хээхэн байгаа. Утмал хиам, гахайн жирээ, чихэр энэ тэр.

-Өө, яах нь вэ дээ?

-Калининд ийм юм чи заяа нь олохгүй. Чи өнөөдөр лав үдийн хоол идээгүй дээ.

-За яахав!

Энэ бүхнийг ээж нь түүнийг ирнэ гэж л зэхээ шүү дээ.

-Юу гээч болж байна даа, Саша минь. Манай байшингаас л гэхэд шөнө алгасахгүй барих юм гэж Софья Александровна өгүүлэв.

-Шүүн таслах ажиллагааны тухай Москвад юу гэж ярьцгааж байна даа?

-Ярьцгаах ий? хэмээн Софья Александровна хямсайсхийв. -Сашенька минь, бүх хүн айж

бэргээд, одоо хэн ч, хэнтэй ч, юу ч ярихаа больсон. Шөнө орондоо орсон хойно нөхөр нь авгайдаа юмхан шивнэвэл их юм, гэхдээ хананаасаа айгаад хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрч байгаад тэр шүү дээ. “Хананд ч сонсгол бий...” гэх цэцэн үгийг мэднэ биз дээ. Тэр шүүх хурал дээр чинь гадаадынхан их олон байсан, Лион Фейхтвангер байсан, элчин сайд нар оролц-сон, өмгөөлөгчид байсан, нөгөө цуутай Брауде үг хэлсэн... Чамд юу ярихаа мэдэхгүй байна, би Варятай л хоёр гуравхан үг сольсон, гэвч Варя өөрийнхөө санаанаас буцах биш. “Вышинский бол бял-дууч, зуйрган, панзны турсага, ер нь энэ бүхэн бүгд худлаа, бүгд хуурамч зүйл, Троцкийн захиаг нотлох баримт болгоод байсан, гэтэл тэр захиаг нь Радек шатаачихсан болж таарсан...” гээд л ширүүлж байна лээ.

Саша инээвхийлэв. Варя нэг удаа ангийнхаа Лякин гэгч хүүхдийг ховын тулам, долдой гэж зад шүүмжилж байсныг Саша санах билээ. Тийм учраас Вышинскийг зүхэж байхдаа Варя ямархан шазруун царайтай байсныг тэр даруй төсөөлөн бодов. Т ү ү н и й Варя ухаантай бүсгүй, яг зөв хэлсэн байна.

-Гэхдээ, Сашенька минь, олонхи нь үүнд итгэж байх шиг санагдах юм. Олон түмний сэтгэл зүй тогтворгүй, түүнийг хааш нь ч эргүүлсэн болно. Чи Травкиныхныг санаж байна уу? Манай байшинд байсан ганц охинтой эмгэнийг? түүний том охин нь эсер ч бил үү, меньшевик ч бил үү, аль хорин хоёр онд шоронд орсон юм... Тэгтэл одоо, арван таван жилийн дараа тэр чавганцыг бага охинтой нь цөлчихсөн. Яасан гэж тэр вэ? Ардын дайснуудтай холбоотой байсан гэж. Тэр ардын дайсан гэдэг нь арван таван жил барааг нь ч хараагүй төрсөн охин нь. түүнээс гадна, бод доо, бүх орон сууцыг ДЯАК-ынхан өөрсөддөө авчихсан. Өө, тийм, Юра Шарок ДЯАК-д ажиллаж байгаа, том түшмэл, дотроо бодолтой байгаарай.

-түүний тэнд ажилтайг би захианаас чинь ойлгосон. Тэр одоо хэрнээ манай байшинд хэвээрээ юү?

-Нүүсэн. Шинэ байр авсан. Хуучин байрандаа эцэг, эх хоёр нь ахтай нь цуг үлдсэн, ах нь Володька, эрүүгийн хэрэгтэн, шоронгоос эргэж ирсэн, уул нь тийм хүнд Москвад суух зөвшөөрөл олгодоггүй, гэтэл түүнд шууд олгосон гэж байгаа, зүгээр ч үгүй, тусгай дэглэмтэй Арбатад тэр шүү.

-Тэгвэл хэрэгтэй хүн нь байх нь гэж Саша өгүүлэв.

-Новшийн гайхал! Ялтан царайлсан, эрээ цээргүй амьтан, зөрөөд өнгөрөхөд л хутга дүрчих гээд байх шиг санагддаг юм. Ингэхэд, чамайг сураглаж байсан шүү.

-Өө, тийм үү?

-Инээх маяг үзүүлээд, “Сашенькагаа ирэхийг харж байна уу?” гэж байна лээ.

-Чи юу гэв дээ?

-Би түүнд, “Чиний ирэхийг үзсэн юм чинь Сашаг ч үзнэ дээ” гэж хэлсэн. Зогсоо ч үгүй, явуул л тэгж хэлсэн... Москвагийн эрүүгийн мөрдөн сурвалжлах газар ажилтай гэлцдэг юм... За,

-Тэр яахав, би энэ хавийн юмыг л бураад байна... Өршөөнө биз. Чи яаж шуухан явна?

-Би сайн, сайн. Харж байгаа биз дээ, амьд мэнд, эрүүл саруул байна.

-Чамайг байдлыг мэдэж аваг л гэж саяныхыг ярьж байгаа юм.

-Төсөөлж байна аа.

-Чам шиг улсыг мөрдөж мөшгинө, юухнаар ч бол өөнтөглөнө. Сашенька минь, мэдээтэй л байж үзээрэй. хүн амьтантай маргах, харгалдахын хэрэггүй. Чи ямар ажил хийх санаатай байна?

-Юу бүтэхээс л болно. Жолооч л зүгээрсэн. Мартсанаас, миний жолоочийн үнэмлэхийг авчирсан уу?

-Өө, авчралгүй яахав. Чамд өгөхөө золтой л мартчихсангүй гээд цүнхээ ухсанаа бас нэг дугтуй гаргаж ирэв. -Энд жолоочийн үнэм-лэх чинь байгаа, дүнгийн дэвтэр чинь энэ байна, нөгөө миний ярьж байсан хоёр хаяг энэ цаасан дээр байгаа, хар даа, бас үйлдвэрчний батлах чинь энэ байна, хугацаа нь мэдээж, дуусчихсан, гурван жил татвар төлөөгүй юм чинь.

-Зүгээр гээд Саша дугтуйг авлаа. -Бүгд хэрэг болж мэднэ.

Тэрээр бичиг баримтаа үзэв. Ногоон хавтастай жолоочийн үнэмлэх, ёстой хүүхдээрээ байх үеийн зураг нь байна, багш нарын танил танил гарын үсэгтэй дүнгийн дэвтэр, бүх шалгалтаа өгчихсөн, зөвхөн дипломынхоо ажлыг л хамгаалж амжаагүй...

-Бас өөр хэдэн бичиг баримт чинь энд байгаа хэмээн ээж нь өөр нэг дугтуйтай цааснуудыг үзүүлэв. -Төрсний гэрчилгээ, дунд сургуулийн гэрчилгээ, биеийн тамирын нэг нийгэмлэгийн гишүүний батлах...

-Наадуул чинь хэрэггүй ээ, чамд байж байг, үгүй ээ, аль вэ байзаарай, төрсний гэрчилгээгээ авъя.

Шинээр паспорт авах боломж гэнэт олдвол төрсний гэрчилгээ хэрэг болж таарна.

-Сашенька минь, чиний сэтгэлийг зовоомооргүй л байна, гэхдээ хэлэхээс яахав. Манай байрны асуудал жаахан төвөгтэй байгаа. Галя жижиг өрөөг авна гэж хөөцөлдөөд салдаггүй. Аавын чинь нэр дээрх баталгааг хүртэл хэрэгсэхгүй царайлна. Намайг мөрдөхийг яана. Чиний захиаг хүртэл дундаас нь олзолж, зохих газар руу аваачиж өгдөг байх гэж би айдаг юм. Тэгээд тусдаа шуудангийн хайрцагтай болсон. Чамайг өөр хотоос утасдахад тэр хүүхэн утас авбал тусгүй. Утасны хорооныхон “Тантай Калининаас ярья гэж байна... Тантай Ленинградаас ярья гэж байна...” гээд л хашгич-дагийг чи мэднэ. Тийм учраас чи баримжаагаар хэдэн цагийн орчим утасдахыг тухай бүр тохирч байя, би тэгээд утасныхаа хавьд байж байна.

-Тэгье ээ, тэгье. Тэндээс Москватай ямар цагт холбодгийг би даан ч мэдэхгүй байна.

-Би ажлаасаа зургаад ирдэг, тэгээд оройжин гэртээ шүү дээ.

-Би маргааш орой долоогоос хойш заавал утасдана, дараа нь тухай тухайдаа тохиролцож байя. Би бас захиа бичнэ шүү дээ, эрхбиш арай хямд тусна гээд Саша инээмсэглэв.

-Тэгэлгүй яахав хэмээн ээж нь санаа нийлэв. -Мөнгөө дэмий үрэхийн хэрэггүй. Ахиухан бичиж байгаарай, болдогсон бол өдөр болгон бичсэн ч яахав. Зөвхөн арга ядсан цагтаа л утасдаж бай. Ингэхэд, Варягийн хаягаар бичиж болно, тэр надад авчраад л өгнө.

-Намайг хайна гэж чи айгаа юу?

-Айх л юм. Тэднүүс ч суллах нь ховор шүү дээ. Сулласан бол буцаагаад барина. Барихдаа ганц чамайг ч биш, найз нөхдийг чинь, бас танилуудыг чинь, тэр ч байтугай, цуг ажилладаг улсыг чинь хүртэл барина. Тэдний систем нь тэр. Аж төрөхөд хэцүү дээ, Саша минь.

-Би тэр тухай мэднэ. Санаа бүү зов. Болж бүтэлгүй яахав.

-Бурхан өршөөх болтугай... гэж ээж нь аяархан өгүүлснээ нүдэнд

нь дахиад нулимс хураад ирэв. -Бурхан минь, яасан ийсэн гэж ингэдэг байна аа?

-Яахав дээ, ээж минь. Би амьд мэнд, эрүүл саруул, эрх чөлөөтэй, ойлгож байна уу, э р х ч ө л ө ө т э й болчихоод байхад чи баярлах ёстой шүү дээ гээд Саша гарыг нь уруулдаа наав. -Миний аз дайрч л тэр үед баригдсан байна, тийм учраас ийм амархан саллаа. Хэрвээ одоо баригдаж байгаа бол, сайнаар бодоход наад зах нь арван жилийн хорих ял авна. Яасан гэж? Бусадтай л адилхан, яагаа ч үгүйн төлөө! Тийм учраас баярлах хэрэгтэй. Юуны ч тухай санаа бүү зов, тайван бай. Би захиа бичнэ, өдөр болгон бичнэ гэвэл худлаа, гэхдээ л бичнэ, харин чи ямар ч нөхцөлд санаа зовж уймрах ёсгүй. Надад муу юм юу ч болохгүй.

Ээж нь чимээгүй сонсон бодлогоширч байснаа ам нээв:

-Вера эгч чинь нэг санал хэлсэн. Чи бүр аргаа барвал 42 дахь километрт байдаг тэдний зусланд очиж болно. Өвөл бол надад урьд-чилж мэдэгдэх хэрэгтэй, тэгээд тэд нар очиж зуслангаа онгойлгоно, тэнд бэлэн түлээ байгаа. Нэг дохионы үг бодож олъё, чамайг тэр үгийг хэлэнгүүт, Верад мэдэгдэх хэрэгтэй болсныг би ойлгоно. Жишээлбэл, “Надад ноосон цамц явуул, би даарч байна”. Ямар вэ, чи юу гэж бодож байна?

-Онц сайн байна. Би тогтоочихъё: “Надад ноосон цамц явуул, би даарч байна” гээд Саша инээмсэглэв.

Ийм юмыг хүртэл урьдаас бодсон байна. мань хүн нэг газраас зулбах хэрэг гарвал энэ их чухал. Эгч ёстой сайн байна! Ах нь буудан алуулсан байхад зээ дүүгээ нууж хаацайлахаас айхгүй байна.

-Онц сайн байна гэж мань хүн давган хэлэв. Тэрхэн зуур тэнд Варятай уулзаж болно гэж гэнэт бодогджээ.

-Варя яаж байна?

-Варя ёстой сайн хүүхэд. Сэтгэлийнх нь сайхныг яана. Би түүнд үнэн сэтгэлээсээ хайртай. Миний ганц түшиг гэж хэлж болно. Чамд явуулсан бүх илгээмжийг тэр л шуудан дээр аваачиж өгнө: “Софья Александровна, танд хүнддэнэ, би өөрөө шуудан дээр аваачаад өгчихье...” гэнэ. Баярлахаас яахав, тийм биз дээ?

Саша толгой дохив.

-Өө, тэгэлгүй дээ...

-Намайг эмнэлэгт аваачиж үзүүлнэ, угаалгын газар байхад тийшээ ирж, өөнтөгч үйлчлүүлэгчдээс намайг өмөөрч үзэлцэнэ. Шазруун охин доо. Тэр л Нинаг албадаж Алс Дорнод руу явуулсан, тэгээгүй бол гарцаагүй баригдах байсан.

-Нина юу?

-Чи бод доо. Нина нам, засагтаа хичнээн үнэнч билээ. Тэдний сургуулийн захирлыг шоронд хийчихсэн, тэр захирал Нинад их сайн, бусад сурган хүмүүжүүлэгчдээс түүнийг онцгойлж үзнэ, үүнээс болоод бөөн хэрэг мандах нь тэр... Варя чемоданд юмыг нь хийж өгөөд, галт тэргэнд бараг хүчээр суулгаад Макс руу явуулчихсан. Товчдоо, Варя ёстой сайн хүүхэд. Гэхдээ их түргэн зантай, толгойдоо юу ч орж ирсэн ярьж л орхино, хэнээс ч бэргэхгүй, би бүр төлөөнөөс нь айдаг юм. түүнд ивээл өмгөөлөл гэж юу ч байхгүй, ядахаар хувийнх нь амьдрал олигтой эвлээгүй...

-Тэр чинь юу гэсэн үг вэ?

-Нэг муу мөрийчин бильярдчинтай суумар болсон, цаадах нь түүний юм хумыг зарна.

Саша чемодан дээрээсээ босч,

-Хөл чилчихэж, жаахан зогсоё, бас тамхи ч татмаар байна гэв.

Тэрээр үнэнхүү гайхширчээ.

-Би түр гараад, хоёрхон сорчихоод ирье, тэгэх үү?

-Тэг, тэг, би хүлээж байя.

Тэрээр буудлаас гарч, хана налан зогсознов. Москва түүнийг мөн догь угтаж байна аа... Марк буудуулчихаж. Будягиныг, мэдээж, бас л буудан ална, гэвч мань хүнд одоо энэ тухай бодох сөгөө алга... Варя, Варя! түүнийг гийгүүлж байсан цорын ганц баяр нь. “Арбатын нүхэнд” түүнтэй бүжиглэж асан нөгөө гоолиг зэгзгэр охин чинь, мөсөн гулгуур руу урьж асан нөгөө энхрий танхил охин чинь нэг муу адгийн бильярдчинтай хоног төөрүүлж байж. Тэр муутайгаа цэнгэж цэнгэчихээд, ширээ рүү сууж, “Чиний одоо юу хийж байгааг мэдэж болдог сон ч болоосой...” гэж бичиж байж. мань хүн л цөллөгт өнчрөн ганцаардсандаа болоод “энхрий”, “танхил” гэхчилэн санаанаасаа юм зохиож, толгойдоо бурхан шиг амьтны дүр

бүтээчихээд, түүндээ мөргөж залбирч байж, ёстой дүйрэн. Тэгж мөрөөдсөөр байгаад тэр охинд дурлачихсан. Үгүй ээ, юуных нь охин байхав? хүний хүүхэнд дурлачихсан болж таарлаа. Зүгээр ч үгүй, хүнтэй дотносохдоо голох шилэхээ мэдэхгүй салхи байж.

Тэрээр дугуу татсан тамхиа цас руу хаяж гишгэчихээд дотогшоо буцаж оров.

-Ээж ээ, би чиний үгийг таслалчихсан, чи Варягийн тухай ярьж байсан.

-Чамд сонин биш байх аа даа?

-Харин ч сонин байна. Цаадах нь тийм мөрийчин юм бол яах гэж түүнтэй суусныг нь ёстой ойлгохгүй байна.

-Учир мэдэхгүй байж л дээ, арван долоохон настай, өнчин өрөөснийг хэлэх үү, бас дугуу гуцуу амьдралтай. Гэтэл гэнэтхэн ресторан, тансаг амьдрал, шилдэг оёдолчид, шилдэг гуталчид, шилдэг үсчингүүд гарт нь ороод ирэх шиг болохгүй юу. Бурхны авралаар, цаг алдалгүй ухаарч, тэр муу зальхайг хөөж явуулсан нь яамай. Тэр хоёр манайд, манай жижиг өрөөг хөлсөлж байсан юм

шүү дээ.

Үгүй ер, нэмэрт нь тэд нар өөрийнх нь байранд сууж, өөрийнх нь ор дэвсгэр дээр унтаж байсан байх нь! Ээж нь яах гэж тэднийг гэртээ оруулав аа, яаж энэ булай явдалд орооцолдож чадав аа?

-Тэгээд яасан?

-Тэгээд үү? Сэхээрч, түүнийг хөөж явуулсан. Тэгтэл ёстой жүжиг шиг мундраа мандах нь тэр. Нөгөөдөх нь Варяг буудаж ална гээд, нэг шөнө гэрээс нь хуурч гадагш аваачсан гэж байгаа. Бараг л багт наадмын хувцастай ирсэн гэнэ лээ. Варя хөхрөөд л ярьдаг юм: Саравчтай малгайгаа нүдээ таглалал дарчихсан, цувныхаа захыг босгочихсон... Гэтэл Варя түүнд, “Бууд, бууд, миний оронд дүүжлүү-рийн шон л авна шүү!” гэж хэлсэн гэнэ лээ. Товчдоо, түүнийг хөөж явуулаад, Нина дээр буцаж очсон, гэхдээ бараг өдөр болгон манайхаар орж гарна. Тэгээд намайг чамд захиа бичиж байхыг харвал шууд л “Аль вэ, Софья Александровна, би Сашад бас нэг юм нэмээд биччихье...” гэдэг юм. Сайхан сэтгэлтэй охин, цайлган шүү, гэхдээ бас л эгэл биш.

Сайхан сэтгэлтэй охин... Үнэхээр ч сайхан сэтгэлтэй юм аа, бас эгэл биш гэдэг нь ч үнэн байх, лав л ээжид нь сайн юм байна, үүнийх нь төлөө Саша түүнд талархах ёстой. Гэтэл мань хүн түүний сайхан сэтгэлийг өөрөө өсгөөд бодчихож. Юунаас болж тэгэв? Варягийн ганц өгүүлбэрээс л болж дээ: “Чиний одоо юу хийж бай-гааг мэдэж болдогсон ч болоосой” гэнгүүт л Варя өөрт нь сэтгэлтэй гээд бодчихож. Тэнэг толгой! Нартад өөр ийм тэнэг толгойтнууд бий болов уу? Нэг муу охины ганц өгүүлбэрт дөрлүүлж амьдралаа зохиох гэж ээ дээ? Ёстой дүйрэн, дүйрэн... мань хүн тийм өгүүлбэртэй захиаг гучин дөрвөн оны сүүлээр, арван хоёрдугаар сард болов уу, авсан. Жавартай өдөр байсныг санаж байна. Зууханд гал ноцож, онигор цонхоор нар тусч байсан, мань хүн тэр захианд ухаан жолоогүй баярлаж,

умгар өрөөн дотроо байх суух газраа олохгүй хөл алдаж байсан. Дараа нь Всеволод Сергеевич ирж, Ленинградд Кировыг алсныг мэдэгдсэн... Киров алагдсан. Маркийг буудан алж. Всеволод Сергеевич алга болчихож... хэн ч алга. Бас Варя ч алга. Нөгөө бильярдчинаа хөөсөн, хөөгөөгүй нь одоо ямар хамаа байна? Толгойдоо барьсан шилэн ордон ингээд бяц үсрэх нь энэ. За яая гэхэв, амьдрал аль ч юман дээр хатуу, энэ тухайд ч хатуу байна.

-Эцэг яаж шуухан байгаав дээ? гэж Саша асуув.

Ээж нь дал мөрөө хавчив.

-Байдаг л янзаараа даа... Ирж байрныхаа зөвшөөрлийг сунгуулсан. Мартсанаас, түр зөвшөөрөл нь гурван сард бүр дуусна. Тэгэхээр Москва руу л шилжиж ирэх байх.

Чимээгүй байзнаснаа,

-Эцэг чинь авгайтай, нэг охинтой болсон гэж нэмж өгүүлэв.

Саша ч тэгж бодож байжээ. Ээж нь энэ тухай бичиж байгаагүй, хүний урманд ганц үг дурсаагүй, сэтгэлийг нь зовоохгүй гэсэндээ тэр. Ээ, ээж минь, ээж минь, цорын ганц төрөлх дотно хүн нь болж дээ. Эцэг эргээд ирвэл ээж яаж шуу амьдрана даа? Зүгээр ч үгүй шинэ гэр бүлтэйгээ эргээд ирэхээр? Байраа сольж таарна, ээжийг нь, хааш нь ч юм бэ, нэг газрын мухрын нүх рүү чихчихнэ. Тэгж байхад мань хүн ээжийгээ өмөөрөх битгий хэл, тус нэмэр ч болж чадахгүй, оготны чоно шиг Оросоор хэрэн тэнэж явах нь.

-Ээж ээ, би чамаас нэг л юм гуйя, эцгийг эргээд ирэхийн цагт өөрийгөө жижгэрүүлж, доромжлуулж болохгүй шүү. Тэгүүлэхгүй гэж ам өчиг надад өг!

-Чамд тийм ам өгье, чи бүү санаа зов. Тэгж ярих юм бол, би байрнаасаа заяа нь гарахгүй. Эцсийн бүлэгт тэр чинь чиний байр, би давын түрүүнд энэ тухай л бодох ёстой гэж ээж нь тогтуухан хэрнээ эрсхэн өгүүлэв. Тэгэхээр энэ талаар аль хэдийн бодлогоо бодож, шийддэгээ шийдчихсэн байх нь.

-За тохиролцлоо! Чухамхүү үүнийг л би чамаас сонсох гэсэн юм.

Саша хэдийгээр хамаг урам нь хийсэх мэт арилсан ч хөгжүүн инээмсэглэв. Уул нь бушуухан галт тэргэнд суугаад, нүдээ тас аних юмсан гэхээс өөр юу ч хүсэхгүй байгаа билээ. Гэхдээ үүлгэртэж, цөхөрч буйгаа ээждээ харуулах ёсгүй. хэн хүнгүй шинэ амьдралтай золгож байна, мань хүн ч ялгаа юу байхав, ээж нь үүнийг дагах л ёстой.

-Ээж минь, та л тайван байхгүй бол би бас таталдаад эхлэнэ. Миний цаашдын төлөв тун дажгүй байгаа шүү, ажил түргэн олно, энэ тухайд би хормын төдий ч эргэлзэхгүй байна.

Ээж нь өөдөөс нь үг дуугүй хараад, ер нь хараа салгах царай алга. мань хүний үг сэтгэлд нь очихгүй байгаа нь тэр. Ээж нь ганцхан юм л бодож байна. Дахиад л хагацах нь гэхээс өөр юу ч бодохгүй байна.

-Чи хоцрох юм биш биз?

Саша ханын цаг руу харав.

-Дахиад хагас цаг бидэнд байна.

-Буудлын цаг дандаа буруу явдаг юм, хоюулаа тавцан руу гарах юм уу?

Саша өөрийнхөө цагтай тулгав.

-Үгүй ээ, яг зөв явж байна. Амжина. Гадаа хүйтэн байгаа, энд дулаан юм. Чи гадаа гарч даараад яахав.

-Хувцас хунар юу явуулахав? гэж Софья Александровна асуув.

-Юу ч хэрэггүй. Надад бүх юм бий. Калининд очоод, байдлыг харж, юмны баримжаатай болсныхоо дараа л чамд хэлнэ.

Саша одоо өөрөө цагаа харав. Тэгээд босч, ээждээ гараа өгөв.

-Галт тэрэг рүүгээ очьё... Хоюулаа цугтаа амьдрахаараа нэг амьдрана, харж л байгаарай гээд Саша ээжийгээ тэвэрч үнсэв.

Ээж нь толгойгоо бөнжигнүүлэн дохив.

-Одоо гэр рүүгээ буц. Би маргааш утасдана.

-Би чамайг гаргаж өгнө.

Тавцан дээр шахцалдахын хэрэг юу байна?

-Би чамайг гаргаж өгнө.

Галт тэрэг хараахан ирээгүй байна. Хэдхэн минут үлдээд байхад галт тэрэг алга хэмээн зорчигчид бухимдан, хараал зүхэл тавих маягтай, тавцан дээр хүн олон, салхи хүүгүүлээд тохь тухгүйг ч хэлэх үү.

Тэгтэл ч бөгсний вагонууд цухуйж, галт тэрэг мурилзан ухарсаар дөхөж ирлээ.

-За, энд салцгаая, тэгэхгүй бол чамайг няц дарчихна, би явж вагоноо хайя.

-Байз, байз, арай эрт байна! гэчихээд Сашагийн араас олны дундуур цөгцөгнөн урагшлав.

Сашагийн суух вагонд зорчигчид хэдийн оочерлочихож. Үйлч-лэгч нь гэж уруулаа будсан, галбалзсан хүүхэн тасалбараа шалган, зорчигчдыг шавдуулж байна.

-Хөдлөөрэй, иргэд ээ, хөдлөнө шүү!

Сашаг үйлчлэгчид тасалбараа өгтөл, ээж нь пальто руу нь нүүрээ наан, хоёр гараараа тэврээд авлаа. Тэр хоёр амьтанд саад болж байгаа учир Саша ээжийнхээ хацар дээр түргэхэн үнслээ.

-Эмээ минь, наад бандийгаа тавьж үз, ямар нэг насаараа салж байгаа биш, амьтан хүний мөр дээр тээглээд гэж үйлчлэгч зандрангуй өгүүлэв.

Ээж нь тавцангаас цаашилж, нэг гэрлийн шон руу очиж налав. Саша вагоны үүдний мухар руу орж, хүнд саад болохооргүй, гэхдээ ээж нь харагдахаар газар зогсов.

Шүгэл тасхийхийн ялдамд үйлчлэгч оочерын сүүлчийн нэг авгайг түлхэн оруулаад вагоныхоо хаалгыг хаалаа.

Галт тэрэг Москва хотыг, энэ буудлыг, ээжийнх нь налан зогсож буй гэрлийн шон энэ тэрийг ардаа орхин хурдаа авч эхлэвэй.

Софья Александровна Сашатай уулзчихаад, бараг гэртээ орж амжаагүй байхад Варя утасдлаа.

-Софья Александровна, та хаачив аа, би хичнээн утасдсан гээч...

-Би т ү ү н т э й уулзаад, гаргаж өгөөд ирлээ гэж Софья Александровна хариулав. Тэр маань өглөө утасдсан, би тэр дор нь чам руу залгасан. Чамайг дөнгөж арван нэгт ирнэ гэж наадуул чинь хэлсэн, гэтэл түүний явах болчих гээд. Би тэгээд явахаас өөр үггүй болсон.

-Ээ, заяа нь орхи, намайг ганцхан цагийн ажлаар Моспроект руу явуулсан юм, яасан тоогүй юм бэ! хэмээн Варягийн дуу сулраад явчихав.

-Битгий гутар, одоо тэр маань ойртоод ирсэн.

-Би ажлаа тараад шууд очъё, та юу болсноо ярьж өгөөрэй.

-Хичээлээ тараад уу?

-Сургууль руу очихгүй ээ. Ажлаасаа шууд танайд очно.

-За, за. Би хүлээж байя.

Варя нэг их бачимдсан, яарсан, тэвдсэн хүн гүйж ирлээ.

-За, мань хүн ямар шуухан байна?

-Дажгүй шүү, амьд мэнд, эрүүл саруул, хөгжүүн, хөхиүн гэх үү. Чи гадуур хувцсаа тайч, халууцна, би чамд цай хийж өгье.

-Цай яахав, амжина, та эхлээд бүх юмаа ярь гэж хэлэнгээ Варя пальтогоо өлгөж, алчуураа тайллаа.

-Хамгийн гол юмыг би чамд сая хэллээ. Амьд мэнд, эрүүл саруул, хөгжүүн хөхиүн байна гэж. Санаа сэтгэл сэргэлэн байна. Мэдээж, паспортын хориотой, цөллөгт байсан улс бүгд тийм юм чинь, ганц манай тэрийг тэгж байгаа биш. Калинин руу явж байна, тэнд танилтай гэнэ, ажилд орох горьдлоготой юм байх. Утасдана гэсэн, чамд мэнд дамжуулсан шүү.

Варя анхааралтай сонсож байлаа. Мэнд байна, эрүүл байна, хөгжүүн байна, сэргэлэн байна, мэнд дамжуулсан энэ тэр гээд бүх юм сайн сайхан юм шиг. Тэгсэн хэрнээ нэг л дутмаг санагдана, Варя энэ бүхнийг арай өөрөөр төсөөлж байсан билээ. Софья Александровнагийн яриан дундаас нөгөө зун цагийн нар ээсэн сайхан зүлгэн дээгүүр гар гараасаа хөтлөлцөн алхах Сашагаа олж харсангүй.

Хэрэвзаяа тэр хоёр галт тэрэгний буудал дээр уулзсан бол, тэр даруй Софья Александровнагийн нүүрэн дээр хоёр биен рүүгээ ухасхийж тэврэлдэн золгох байсан, тэгсэн бол орчлон хорвоо шал өөр болж, аливаа бэрхшээл зовлон нь яль шальхан, аахир шаахир,

өчүүхэн зүйл болж хувирахгүй юу. Тэр хоёр яг л ингэж золгоно гэж Варя төсөөлж асан атал, өчигдөр хэн нэгэн Моспроект-д нэг муу зурагны хуулга мартчихсанаас болоод түүнийг олж ирэх гэж салгалж яваад, энэ уулзалт санаснаар болсонгүй.

Варя сэтгэлээ чангалж биеэ барив. За яахав, юу эс тохиодог билээ, өөрийнх нь аз дугааж. Калинин энүүхэнд байгаа нь л олз, ирэх бүтэн сайнд л тийшээ явах юм шүү.

-Та надад тодорхой ярьж өг л дөө гэж Варя Софья Александровнагаас гуйв.

-За өөр юусан билээ, Варенька минь, манай хүн сахал үс нь ургасныг эс тооцвол огт хувираагүй байна, ойрд сахлаа хусаагүй гэнэ, бараг бүтэн сар явсан юм байна. Ямар тайван, ямар эрэлхэг байв аа, би ёстой гайхлаа. Марк Александровичийн буудуулсан, Будягины баривчлагдсан энэ тэрийг хэлэхэд ёстой ажраагүй; намайг уймруулахгүй гэсэндээ л тэр, андашгүй байна лээ. Цаадах чинь Марк, Иван Григорьевич хоёрт хоюуланд нь их сайн шүү дээ. Шүүх хуралдааны тухай асуусан. Ойрын найр сонин уншаагүй гэнэ. Жолооч хийх санаатай юм байна, тэр нь ч зөв гэж би бодож байна, бичиг цаас шалгах нь арай гайгүй байх. Өө, бас, тэр жил баригдсан нь аз, одоо бол арван жилээр заагдах байсан гэж байна лээ. Товчоор хэлбэл, бүх юмаа ярилцсан, би мөнгө өгсөн, нөгөө чиний авсан идэх юмыг өгсөн, хэзээ утасдах, элдэв юм тохиовол яаж мэдэгдэх энэ тэр гээд бүх юмаа тохиролцсон.

-Намайг асууж байна уу?

-Асуулгүй яахав, Варя минь, чи юу ярьж байна?

-Юу гэж асууж байна, яг юу гэж байна?

-Яг уу?.. “Варя яаж шуу байна?” гэсэн, яг шулуухан “Варя яаж шуу байна?” гэж асуусан.

-“Варя сайн биз дээ” гэсэн байлгүй.

-Үгүй ээ, яг л “Варя яаж шуу байна?” гэсэн. Юу гэж цаадах чинь тийм тоомжиргүй асуухав, Варя минь, тийм биз дээ? Ярихгүй! Яг л миний хэлж байгаа шиг “Варя яаж шуу байна?” гэж шулуухан асуусан.

-Та тэгээд юу гэв?

-Чиний тухай бүгдийг нь ярьж өгсөн гээд Софья Александровна инээв. -Би чиний тухай юу ярьж чадах билээ? Ганц л юм чадна, чамгүй бол би балрах байсан, тэсэхгүй байсан.

-За, боль доо, та.

-Үгүй, үнэн юм чинь! Саша ч үүнийг ойлгож мэдэж байгаа, тэгээд чамд талархаж байгаа. Варенька, би Нинагийн тухай түүнд ярьсан, зөв үү?

-Зөв байлгүй яахав.

-Чиний ямар анхаарал халамжтайг ярьсан, эрэлхэг зоригтойг чинь ярьсан, Нинаг яаж Макс

руу албадаж явуулсан, хүчээр явуулсан гэж хэлж болно, бас Костяг яаж хөөж явуулсан энэ тэр...

-Юу гэнэ ээ, юу гэнэ ээ? гэж Варя үгийг нь тасдаж асуув.

-Яахав, Костяг яаж хөөж явуулсныг чинь гэж хэлэнгээ Софья Александровна өөрөө ч ойлгохгүй гэнэтхэн сэтгэл нь түгшээд явчихав.

Варя түүнийг ширтсэн чигээрээ,

-Костяг тэр яаж мэдээв? гэж асуув.

-Юу... юу гэсэн үг вэ гэж Софья Александровна самгардан өгүүлэв. Болгоомжгүй хэрэг тарьснаа сая гэнэт ухаарав.

-Костяг тэр яаж мэдээв? гэж Варя давтан асуув. Амьсгаа нь юу юугүй дээшлээд ирлээ.

-Юу л даа... би л ярихгүй юу.

-Юу, та түүнд юу ярьсан юм бэ? хэмээн Варя түүн рүү тонгойн хашгирав.

-Варенька, чи яачихав, тайвшир! гээд Софья Александровна өмгөнөн агаар залгиснаа зүрх нь өвдөв бололтой гар нь эм рүүгээ зүглэв.

Варя түүний байдлыг анзаарахтай мантай, нөгөө л тонгойсон чигээрээ,

-Юу, та түүнд юу ярьсан юм бэ? гэж дахин хашгичив.

Софья Александровна санаашрав.

-Варенька, би гойд юм яриагүй ээ. хүнтэй суусан, манайд сууж байсан, дараа нь чи түүнийг хөөж явуулсан, цаадах чинь чамайг алах гэсэн, гэвч алуулдаг нь чи биш... Аль хэзээний, бүр хоёр жилийн өмнө болсон явдал гэж хэлсэн.

Варя хоёр гараараа нүүрээ таглав:

-Ээ, халаг минь, та яах гэж түүнд юм ярив аа? Яах гэж? Яана бол доо?

-Үгүй, Варенька минь, энэ чинь бүгд үнэн шүү дээ, Саша эрт орой хэзээ нэгэн цагт мэдэж л таарна, чи өөрөө ч гэсэн түүнд ярих байсан биз хэмээн Софья Александровна аяархан өгүүлэв.

Варя нүүрнээсээ гараа авч,

-Тийм ээ, ярих байсан, гэхдээ ө ө р ө ө, ойлгож байна уу, өөрөө ярих байсан юм. Би тайлбарласан бол тэр ойлгох байсан гэв.

Тэгснээ дахиад нүүрээ таглав.

-Ээ, халаг минь, та ямар хэрэг тарьчихав аа?! Ямар хэрэг тарьчихав?!

Софья Александровна дуугарсангүй. Эм нь хараахан үйлчлээгүй учраас зүрх нь шимширсэн хэвээр, бас толгой нь жаахан эргэж байна, ингэсхийгээд намдах байгаа даа, сандал дээрээс л уначихгүй юмсан, ээ, багш минь.

-Варенька, тайвшир, охин минь, чамаас гуйя. Саша бэртэгчин биш гэдгийг чи мэднэ шүү дээ. Чамд ч, түүнд ч юу эс тохиож явлаа. За, тайвширч үз, би гуйж байна шүү.

Варя юу ч хэлэлгүй пальтогоо шүүрч авав.

-Варенька, чи хаачих нь вэ, хүлээзнэ!

-Үгүй ээ, баярлалаа, миний цаг болчихож.

Тэгээд нулимсаа барьж ядан гүйж гарлаа.

Софья Александровна бодолд автав. Ээ, чааваас, яагаад энэ бүхнийг анзааралгүй, сохор юм шиг өнгөрчихөв? Варя сэтгэлтэй болчихоод, ямар нэг горьдлого, найдвар өвөрлөж байж... Манай Сашад бол сайн авгай болох байсан байх... Зоргоороо, эрэлхүү, заримдаа догшин, түргэн зантай, гэхдээ өрлөг. Эмэгтэй хүнд баймаар гол шинж бол өрлөг сэтгэл гэж Софья Александровна боддог билээ. Одоо бол Саша гэр бүлийн тухай бодох цаг, мэдээж, биш, гэхдээ Варя бол түүнд дараа болохгүй, харин ч дараа гэхээсээ урьдаар түшиг тулгуур болно. Хэрвээ Варя ямар нэг горьдлого өвөрлөж байсан бол, юу гэж нөгөө Костягийн тухай, тэр ёозгүй явдлын тухай Сашаг мэдээсэй гэж бодох вэ, тэр аргагүй.

Зүрх нь жаахан тавирах шиг болж бас толгой эргэх нь ч овоо намдлаа. Софья Александровна зөөлхөн босч, орон дээрээ хэвгэв. Нүдээ анитал дахиад толгой нь эргэлээ. Үгүй ээ, нүдээ аньж болохгүй. Цээжний бахнаас болж ингэдгийг мэдэж байвч, үхэх нь гэсэн айдас түүнийг эзэмдэж, орон дээрээсээ дахиж босохгүй, ингээд үхэх юм шиг санагдав. Тэнгэр минь, ингээд үхэх нь. Төвхнөөгүй Сашагаа орхиод. Орчлон дээр орь ганцаар нь орхиод.

Халааснаасаа хуруувчин шилтэй зүрхний эмээ тэмтэрч олоод нэг үрэл авч хэлэн дороо хийв.

Тэрээр Варяг ойлголгүй яахав, Варя Сашад хайртай сэтгэлтэй юм байна, тэгэхээр Костятай холбоотой тэр юмнаасаа ичих нь түмэн зөв. Гэтэл хайр сэтгэлийнхээ тухай яагаад юу ч ярихгүй өдий хүрэв ээ? Сашаг баригдсан өдрөөс эхлээд л өөрт нь тусладаг болсон, ингэж тус нэмэр болж байгааг нь сайхан сэтгэлтэй, буянтай охины ач гэж бодож байснаас бус, Сашад сэтгэл алдсан охины тус гэж даанч бодоогүй. Варя суруулиа төгсөөд, цэргийн хүнтэй сууж, түүнийгээ дагаад Алс Дорнод руу явна гэж бүр Сашаг баригдсанаас хойш ярьдаг байсан шүү дээ. Дараа нь дэслэгч сураггүй болж, Костя гарч ирсэн, гэтэл тэр дэслэгчийн үед ч, Костягийн үед ч Варя өөрт нь анхаарал халамж тавьж, угаалгын газар нь ирж тусладаг, Сашад явуулах илгээмжийг шууданд хүргэж өгдөг энэ тэр байсан шүү дээ. Хэдийд нь Сашад сэтгэлтэй болчихсон юм бол? Эсвэл өөртөө эрэмшсэн бардам охин нэр нүүрээ барахаас айж,

Саша өөрийнх нь тухай бүү муу юм бодоосой гэсэндээ зүгээр ингэж байгаа юм уу? Гэтэл, ээ бурхан минь, хичнээн охид ийм алдаа хийж яваа билээ дээ. Явж явж “нөхрөө хөөж явуулсан” гэдэг үгэнд л эмзэглэж гутарсан байх, төлөв төвшин хүнийг хөөж явуулна гэж байхгүй, төвшин хүмүүс бол мөрөөрөө салцгаана. Тэгэхээр Варя журамгүй хүнтэй суусан болж таарч. Нээрэн, Софья Александровна үгээ ололгүй болгоомжгүй юм хэлсэн байна. Энэ бол алдаа. Гэхдээ үүний төлөө тэглээ эмзэглэхийн хэрэг юу байна?

Тайвшрах хэрэгтэй байна, тайвшрах. Юуны өмнө, Сашагаа бодох ёстой, одоохондоо өөрийнх нь дэмгүй бол Саша мөхөсдөнө. Варя сайн охин, гойд сайн охин, өөрөө ч түүнд хайртай, ээж шиг нь хайрлаж яваа, гэхдээ түүний адармаалах тоолонгоор бухимдаж байх ёсгүй. Мэдээж, Варягийн аж амьдрал амаргүй байгаа, зөвхөн Нинагийн явдал гэхэд л яаж зовлоо доо. Охиныг ойлгож болно. Тэглээ ч гэсэн арай тавьгартай байх хэрэгтэй.

Софья Александровна ийнхүү бодолхийлсээр зүүрмэглэжээ.

Хичнээн унтсаныг бүү мэд, нэг мэдэхэд гэрт нь хүн байх шиг санагдаад сэрчихэв. Гэтэл орных нь хажууд Варя сууж байв. Варя түүн рүү инээвхийлээд орны урд руу унжсан гарыг нь дээшлүүлж атгав.

-Таны бие яаж байна, Софья Александровна?

-Зүгээр ээ, охин минь, дажгүй.

-За, яамай даа. Би таны унтаж байгааг хараад л сууж байсан юм. Та намайг уучлаарай, Софья Александровна, өршөөгөөрэй. Би буудал руу очиж, Сашатай уулзаж чадаагүйдээ болоод тэр үү, голын хий хөдөлчихгүй юу. Би уул нь үнэхээр уулзъя гэж бодсон юм. Бас тэгээд... Костя бид хоёрын тэр нэг ой гутам явдал байна, би өөрөө ч тэр тухай дурсах дургүй, хүн ч битгий дурсаасай гэж боддог юм, тэр тухай Сашаг мэдсэнийг дуулахад их эвгүй байсан, ийм байдлаар түүнд өөрийгөө харуулмааргүй санагдсан юм.

-Гэхдээ, Варенька минь, би муу юм юу ч хэлээгүй. Саша үүнийг ойшоож үзээгүй, нээрэн шүү. Надад ч утасдана, чамд ч утасдана гэж хэлсэн.

-Тэгж хэлсэн үү?

-Тэгэлгүй яахав. Заавал утасдана. Над руу утасдана, тэгэхэд нь хэзээ утасдах тухай тохирчихоод би чамд хэлнэ, за юу?

-Тэгье, тэгье гэж Варя хариулахдаа Софья Александровна өөрийг нь тайтгаруулах гэсэндээ ийм юм одоо бодож олж гэдгийг гадарлав. Гэвч одоо түүнийг юу ч тайвшруулж чадахгүй. Амьдрал нь нэгэнт үрэгдсэн, Саша Костягийн явдлыг уучлахгүй. Хэдийгээр цөхрөн бухимдсан хэвээр байгаа ч Софья Александровнагийн зүрхний хууч дахиж хөдлөхий гэж айгаад хүчлэн байж инээмсэглэв.

Софья Александровна дэрэн дээрээ өндийсхийн суув.

-Тийм учраас ямар ч муу юм болоогүй, битгий гутар, нээрэн шүү.

-Тийм ээ, тийм, би ойлгож байна. Тэр муу Моспроект руу тууж явуулсанд л дургүй хүрээд байгаа юм, хоёр долоо хоног туж ажлынхаа өрөөнд байж байгаад, ганцхан цаг гараад ирсэн чинь яг тэр хооронд Саша тань руу утасдсан байгаа юм, би тэгээд л бухимдчихгүй юү. Нэмэрт нь таныг бас уймруулчихлаа гээд Варя Софья Александровнагийн гарыг илэв.

-Чиний орж ирэхийг би мэдсэнгүй шүү.

-Софья Александровна, танай түлхүүр надад бий шүү дээ, та мартчихаа юу?

-Өө, нээрэн, тийм шүү дээ.

-Харин энэ өрөө чинь түгжээгүй байна лээ, гэрэл асаатай бай-хаар нь би орж ирээд, өлмий дээрээ сэмхэн явж, таны ор руу ирсэн юм. Гэртээ хариад жаахан тайвширч, таныг үймүүлчихсэнээ ойлголоо л доо, тэгээд миний муу Софья Александровна яаж байгаа

бол, буцаж очиж харъя гэж бодоод ирсэн юм.

Софья Александровнагийн нулимс нь цийлэгнээд ирлээ. Варягийн гарыг тавилгүй, байгаа тамирынхаа хэрээр атгав.

-Эвий, миний муу сайхан сэтгэлт, хонгор охин.

Саша ээжтэйгээ салах гэсээр байгаад, вагонд суудал эзлэж амжилгүй, сандлын булан дээр суухчаан аядав.

Толгойноос Марк салж өгдөггүй, Будягин, бас тэдний байшингийн хөөрхий Травкиныхан толгойноос салдаггүй. Улс орон сэтгэл санаад багтамгүй, үнэхээр аймшигтай самуурч байна, сонин хэвлэлийн хийрхлээс үзэх юм бол энэ бүхэнд эцэс төгсгөл гэж байхгүй нь. Ямар ч атугай ээжтэйгээ аятайхан байлаа, тайван байж чадсан учраас ээж нь бага боловч сэргэлээ. Ээж нь ч түүнийг ганцаардуу-лахгүй, хэрэгтэй бол хамаатан садан, ойр дотныхон нь тусламжийн гараа сунгана гэж итгүүлэх, өөрийнх нь итгэлийг тэтгэх гэсэндээ болоод тун туйлбартай байна лээ.

Варягийн тухай ээжийнхээ ярьсан юмыг ч шантралгүй сонссон, царайгаа хүний урманд өчүүхэн ч хувьсхийлгээгүй, ээж нь юу ч гадарлаагүй.

Гэтэл одоо түүнийг Москвагаас, өөрийнх нь Москвагаас хүний Калинин руу аван одож буй пиг дүүрэн вагон дотор, үл таних хөндлөнгийн хүмүүсийн дунд сэтгэл санаа нь хоосрон, хөсөр хаягдсан мэт зовиурлан гансрах нь тэр. Ээжтэйгээ уулзахдаа тайван байх гэж аргагүй их чармайсан бололтой, одоо хамаг бие нь сулбайчихжээ. Тэрээр сандлын аравчийг налан нүдээ анив. Замын хүмүүс хоорондоо хүүрнэлдэж, эсрэг талд нь суугаа хэдэн залуу хөсөр балбан хөхрөлдөж байвч, мань хүн товлон сонсож байгаа юм алга, нэг бодол нөгөөгөөр солигдон, эцсийн бүлэгт өөрийг нь чухам юу нөмрөөд авсныг ойлгох гэж оролдов.

Цөллөгийн хугацаа дуусах үес өөрийг нь юу хүлээж буйг мэдэж байсан билээ. Тайгын замд чарганы араас алхаж явахдаа, туугдсан хоригдлуудыг харж байхдаа, Тайшетэд радио чагнаж байхдаа энэхүү харанхуй хар самууныг мэдэрсэн бөгөөд ямар ч санаандгүй юмтай тулгарахад дотроо бэлэн байсан. Москвад, ээжийгээ хүлээж байх хооронд нь галт тэрэгний буудал дээр хомроголосон баривчилгаа гэнэт эхлэж, түүнийг паспортын дэглэм зөрчсөн гэдгээр барьж мэдэх л байсан. Юутай ч тулгарахад бэлэн байсан, гагцхүү ийм юм л болно гэж даан ч бодоогүй.

Гэхдээ Варяг буруушаах эрх байхгүй. Тэр бүсгүй өөрт нь ямар ч ам өгөөгүй, ямар ч үүрэг аваагүй, тэр хоёр хайр сэтгэлийн тухай ганц ч үг сольж яваагүй юм чинь түүнийг урвасан хөрвөсөн гэх үндэс алга, мань хүүхэнд ямар ч холбогдол алга. Саша өөрөө л

түүнийг з о х и о ж, тийм дүрийг өөрөө л бүтээж. Хэдий тийм ч гэсэн нэг муу мөрийчин өөрийнх нь өрөөнд сууж байж, өөрийнх нь буйдан дээр түүнтэй унтаж байж гэхээс, үдшийн цагаар шүүгээнийх нь араар унтраалга хайж, муухай савраараа ханан дээгүүр тэмтэрч байж, тэгээд харанхуйд түүнийг дарж авч байж... гэхээс зүрх нь өөрийн эрхгүй шархирна. Ээ, халаг минь, хардах гээчийг амьдралдаа анх удаа үзэж байна, уул нь юу байдгийг даанч мэдэхгүй явсан сан, юу эсийг ханаж цадталаа амссан билээ, одоо энэ л дугааж гэнэ дээ, ёстой больё, чи минь!

Калинины тухай, яаж ажил хайх тухайгаа л бодох хэрэгтэй. Эхлээд Ольга Степановна дээр очно, байр сууцны талаар ямар нэг зөвлөлгөө өгөх байх. За, Ольга Степановна дээр очно, энэ

ч тодорхой байна. Харин тодорхойгүй өөр нэг юм байна: тэр хоёр ээжийнд хэр удаан суусан юм бол, тэр тухай асуусангүй. Асуух минь яав аа? Гурван сар уу, зургаа юу, бүтэн жил үү? Бодол санаа нь ийнхүү Варя руу, бильярдчин руу буцаж хургаад болж өгөх юм биш, ийм балай бодол тонилвол таарна, ингэж өөрийгөө доромжлохын хэрэг юм байна. Үгүй ээ, санасны зоргоор болдоггүй юм байна, ингэж байхаар үхэх минь. Яасан гэж үхэх вэ, яасан гэж? Ээжид нь тус болж, илгээмж энэ тэрийг нь шуудан дээр хүргэж өгч, хааяа ээжийнх нь захианы төгсгөлд хоёр гурван найрсаг өгүүлбэр тавьдаг байсан нэг охиноос болж тэгэх үү? Ганц үнсэж ч үзээгүй охиноос болж уу? Ямар тэнэг, ямар ичмээр хэрэг вэ? Тэгсэн хэрнээ бодлоо барьж чаддаггүй.

Галт тэрэг нэгэнтээ хүчтэй дайвалзаж, Саша сандлынхаа ирмэгнээс зуурч, гараа өвдтөл базав.

Тэр муу нохойн гөлгийг баруун зүүн хоёр талаас нь нэг нэг сайн хульхидах юмсан, хамар нармайг нь нээж цус нөжтэй нь хутгах юмсан, Варяг нь булааж авна гэнэ ээ, муу хүний адаг. Сашаг Мозговад үйлээ үзэж байхад, тэр муу мөрийчин өрөөнд нь аж төрж, эд бахаа хангаж, элдвээр цэнгэн тансаглаж байсан байна, тийм замаар Варяг уруу татаж, худалдаж авсан байна... Тэр мөрийчин өөрийг нь мэдэхгүй, Саша гэж хүн байдгийг мэдэхгүй, гэхдээ тэр ямар хамаа байна, Саша түүнийг үзэн ядахаас өөр яахав, томоогүй охиныг ресторанаар хуурч, мөрийтэй тоглоомын газар хэсүүлж, бооцоогоо хөөрлөж, балиар муухай савраараа тэврээд л... Өөр газар бол ч яая гэхэв, очиж очиж өөрийнх нь ор дэвсгэр дээр шүү... Бол оо! Гүйцээ! Варяг толгойноосоо таягдан хаяя, бодох, дурсахаа нэгмөсөн больё! Энэ явдал ингээд дууслаа!

Саша нүдээ нээж цонхоор харав. Цас, эргэн тойрон цас, ямар гунигтай юм бэ...

Саша Калинины галт тэрэгний буудал дээр чемоданаа тээш хадгалах газар өгөв. Ольга Степановна дээр чемодантай очвол заавал хонох гэж байгаа юм шиг болчихно, нөгөөтэйгүүр тэднийд танихгүй хүн ирж байгааг айлынхан нь харчихна.

Чемоданыхаа түлхүүрийг аль хэдийн хаячихсан болохоор зүгээр л түгжээгээр нь оньсолчихно. Гэтэл цоожгүй чемоданыг хадгалах газар хүлээж авахгүй. Саша буудлын талбай хавиас нэг чулуу олж, чемоданыхаа хоёр түгжээг хотойтол цохив. Оньсыг нь дарж үзвэл онгойх царай алга. Хайран юм, гэвч яая гэхэв, хадгалах газар л өгч байвал бол оо, дараа нь засварчинд аваачаад засуулчихна.

Тээш хүлээн авагч чемоданы хоёр түгжээг дарж шалгав. Саша бичгээ авч, Степан Разины эргийн өргөн чөлөө рүү яаж очдогийг лавлаад буудлын байшингаас гарлаа.

Саша урьд өмнө Калининд ирж байгаагүй болохоор хөдөөний бөглүү хот байх гэж бодсон юмсанж. Цэвэрхэн сайхан хот байхыг үзээд баярлах, гайхах зэрэгцэв. Тэрээр Зөвлөлтийн гэх гол гудамжаар өгсөн, гурван ч талбайгаар дайрч гарав. Лениний нэрэмжит цэцэрлэгтэй Улаан талбай, Зөвлөлтийн талбай, Пушкины талбай. Лениний талбай дээр Хотын зөвлөл, хотын намын хорооны тусгай байшингууд, бас театр байна.

Гудамж сайхан цардмал замтай, явган замын цасыг сайхан цэвэрлэчихэж. Трамвай явж байна. Москвад гурван жилийн өмнө үзсэн ГАЗ-АА, ЗИС-5, ГАЗ-ын хөнгөн тэрэг энэ тэр

давхилдаж байна. Харин хотын намын хорооны ойролцоо М-1 буюу “эмка” гэдэг хөнгөн тэрэг, мужийн гүйцэтгэх захиргааны тэнд ЗИС-101 гэдэг суудлын урт хар машин зогсож байна. Саша ийм машин үйлдвэрлэснийг сониноос уншсанаас биш нүдээрээ хараагүй билээ.

Москватай яаж зүйрлэх вэ, гэхдээ Канск, Кежма юм уу, Тайшеттэй жиших юм бас алга. Инээд гэрэлтсэн царайтай хүмүүсийг ойрын найр хараагүйг хэлэх үү, эндэхийн хүмүүс алхаж гишгэх нь хүртэл тайван, ер нь сэтгэл тэнэгэр, хэвийн амьдрал мэдэгдээд байх шиг.

Үсчний газрын сандал, толь, буланд буй удамбар цэцэг, дулаахан, тохилог байгаа энэ тэр нь яг л Москвагийнх гэсэн үг. Үсчин Сашагийн үсийг засч, сахлыг нь хусч, нүүрэнд нь халуун жин тавьж өгөв. Боловсон аж төрөх ч сайхан юм аа, золиг чинь. Одоо хүний нүүр харахтайгаа боллоо. Уул нь энэ ямбий савхин гутлын оронд нарийн эсгий гуталтай бол, мэдээж, догь харагдалгүй яахав, гэхдээ нөхөр Сталин хүртэл савхин гутал өмсдөг юм чинь. Цамцны оронд паравгар ноосон цамцтай, муу пиджак нь ч юу эсийг үзлээ, өмд нь ч дээрдэх юм алга. За яахав, дажгүй. Мозговад өөрөө сахлаа хусч, Всеволод Сергеевичээр ердийн хоёр хурууны хайчаар үсээ засуулдаг байсан, Всеволод Сергеевич ямар юмных нь үсчин байх вэ дээ! Гэтэл түүнийг Красноярск руу авч явснаас хойш ерөөсөө үсэнд хүрэх хүн-гүй болсон, Всеволод Сергеевич одоо ямар лагерьт хоригдож байгаа бол, хэдэн жил өгөө бол? Мэдэх юм даанч алга, уул нь түүнд юухнаар ч болов тус болох сон, үгүйдээн, хэдэн мөнгө гуйвуулах юм уу, илгээмж явуулахгүй юу. Гэтэл баригдсан хүмүүсийн тухай мэдээллийг зөвхөн төрөл төрөгсдөд нь өгнө. Гэвч заримдаа өгөхгүй, зарим хүнд өгөхгүй.

Степан Разины эргийн өргөн чөлөөнд бас л багана энэ тэр болсон, хуучин цагийн хоёр гурван давхар өргөө маягийн байшингууд байх аж. Харин ойрд засч тордоогүй нь илт. Шавардлага нь энд тэндээ ховхорч, будаг сэлт нь халцарч, цаанаа л нэг өгөршсөн царайтай. Байрны дугаар нь 11-а гэж буйг бодоход, Сашагийн хайж яваа өргөөг аль хэдийн нийтийн байр болгоод хуваачихсан нь тодорхой.

Саша яв явсаар хавь ойроор нь цас хунгарлаж, хог новш хөглөрсөн, орцны хаалга нь санжийж онгойсон, шатны хонгил нь харанхуй нэг байшинд орж, ямар ч атугай, 11-а дугаартай байрыг оллоо. Хулдаас нь урагдаж, хөвөн нооройсон хаалгыг тогшив. Дотуур цамцтай, савхин гуталтай, мөрөвчтэй цэрэг өмдтэй эрэгтэй хүн гарч ирэв.

-Уучлаарай, Масловатай уулзах гэсэн юм гэж Саша хэлэв.

Цаадах нь түүнийг цоргих мэт харж,

-Та хааныхын хүн бэ? түүний юу нь юм? гэв.

Манигар нүүртэй, гахай нүдтэй, шижээргүй харцтай ийм лүдийг Саша сүүлийн хэдэн жил ёстой харахаараа нэг болсон доо.

-Та юу нь юм? гэж нөгөө хүн ширүүлэв.

-Юу нь ч биш. Би Пензээс яваа хүн, хөгжмийн сургуульд багшилдаг. Төгөлдөр хуурийн ангид. Надтай цуг ажилладаг нэг багш-Раиса Семеновна Розмаргунова-намайг Калинин явж байгааг

мэдээд, гимназид цуг сурч байсан найз Ольга..., өө, эцгийнх нь нэрийг мартчихаж хэмээн Саша халаасаа уудлан нэг цаас гаргаж, Ольга Степановна Масловагийнхаар ороод, мэнд уламжилж, яагаад захиа бичихгүй байгаа, бие нь сайн, амар мэнд эсэхийг мэдээд ирээрэй гэсэн юм гэв.

-Тэгээд юу гэж?! Тэгээд? гэж асууж байна.

-Өөр юмгүй ээ, ингээд л гүйцээ.

Саша түүний нүд рүү хэнэггүй харж байв.

-Тэр хүүхэн чинь эндээс нүүсэн, аль эрт нүүсэн. Хаашаа нүүснийг нь би мэдэхгүй.

Ингэж хэлээд хаалгаа хаачих нь тэр.

Саша гадагшаа гарав. Бүгд тодорхой боллоо. Кировыг алагдсаны дараа сэжигтэй хүмүүсийг хаа сайгүй барьж эхэлсэн юм чинь, бүр хоригдох гараагаа Соловкоос эхэлсэн ялтны гэргийг яаж зүгээр орхих вэ, Ольга Степановнаг, мэдээж, цөлсөн, эсвэл өөрөө нэг тийшээ яваад өгсөн байх, тэгээд энэ сууцыг нь яамны энэ муу дух эзэгнэчихэж. Шалихгүй түшмэл байх, гэхдээ л түшмэл. Гахай хоншоорлоод, тэр харж байгаа царайгий нь ээ! Аягүй бол, барих уу, болих уу гэж бодсон байх.

Заяа түшлээ!

Түшихгүй ч байж болох шүү дээ. Бичиг баримтаа үзүүл! Би тэр гэгч байна! Тэгээд ДЯАК-ын ажилтны үнэмлэхээ үзүүлнэ. Наашаа ороод ир! Паспорт үзнэ... Өө, иймэрхүү янзын Пензээс яваа байх нь... Ойлгомжтой. Тэгээд утсаа авна: Вася, Володя, Петя, манайд хүрээд ир, миний энд нэг “Пензийн” шувуухай нисч явна, нөгөө Масловаг чинь хайж явна... Аль вэ, бушуухан ир! Тэгвэл хэрэг ундарч өгнө дөө! Масловаг яаж мэддэг юм бэ? Нөхөртэй нь хамт цөллөгт байсан юм уу? Одоо холбоо баригч уу? Туушингаар оруул, гянданд хий, жаварт нүцгэн зогсоо! Муу өлөгчин, үнэнээ хэл, чамаас гадна, Маслов, түүний авгай хоёроос гадна хэн хэн танай байгууллагад байдаг вэ? Ингээд ороочих юм бол тэр муу долдой багагүй нэр төр олох байсан даа. Нэг юм л саад боллоо. Нэг муу хүүхэнцэртэй байсан юм болов уу, хөнжил дотор нь халуухан хүүхэн хэвтэж байгаа бол ч юун тагнуул, юун дайсантай мантай, дайсны төөрөг мэдсүгэй л болно.

Болгоомжгүй, их хөнгөмсөг зан гаргасан байна! Лагерьт байгаа хүний, аягүй бол, аль хэдийн буудан алуулсан эсэргүүгийн гэргийтэй уулзах гэж зүтгэлж. Алферов сануулаад байсан шүү дээ: “Танд олны дунд байх нь зохисгүй, та с а л а н г и д байх хэрэгтэй. Танд илүүц холбоо сүлбээ хэрэггүй, ер нь танд ямар ч холбоо сүлбээ байх ёсгүй...” Энэ удаа нэг юм аргаллаа. Цаашдаа арай хашир байлгүй горьгүй.

Бүрий буугаад иржээ. Саша шонгийн гэрэлд ойртож цагаа харвал таван цагт хэдхэн минут дутуу байна. Хаашаа явах вэ? Ямар нэг гарааш олж, жолооч хэрэгтэй эсэхийг сураглах уу? Танихгүй хотод өдийд гарааш хайх ч арай оройтсон байлгүй. Ер нь боловсон хүчний хэлтэст нь заавал орох ёстой болно, гэтэл тэнд хэн сууж байхыг бүү мэд, саяных шиг торой нүдлэсэн

шидэл рүү давхиад орчихсон байвал яана.

Нээрэн, танил хүнгүй бол ч бүтэхгүй нь дээ. Михаил Юрьевичийн дүү Евгений Юрьевич рүү, Рязань руу явах хэрэгтэй. Евгений Юрьевич гэж сэхээтний үнэр ханхийсэн сайхан нэр. Саша түүнийг бүдэг бадагхан санаж байна. Ах дээрээ ирдэг байсан, Евгений Юрьевич залуу л болохоос, тэр хоёр их адилхан. Журамт хүмүүс учраас тэдний үг найдвартай, итгэлтэй. Аз таараад өнөө шөнө эндээс явчих юм бол, маргааш гэхэд Рязаньд оччихно, Москвагаас тийшээ галт тэргээр их л сайндаа тав, зургаан цаг явах юм чинь. Москвад очингуут Ленинградын буудлаас ганцхан талбай хөндлөн гараад л Казанийн буудал руу орчихно. Михаил Юрьевичийн өгсөн хаягийг ээжээсээ авангуут, төлөвлөгөөгөө өөрчлөөд Рязань руу явчихдаг байж. Яагаад тэгсэнгүй вэ? Калинин явах тасалбараа авчихсан болоод тэр үү? Рязань орох тасалбар олдохгүй, тэгээд Москвад бас хэдэн цаг ёрдойх хэрэг гарна гэсэндээ тэр үү? Гэнэт шийдвэрээ өөрчилвөл, Калининд олигтой барьц байхгүй, чухамдаа явах очих газаргүй юм байна гэж ээж нь ойлгоод бүр санаа нь зовчихно гэж тэгэв үү? Үгүй бол Москвагаас л бушуухан зайлах гэж яарч, галт тэрэгний буудал дээр бүртгэнэж байхаасаа айсан байх нь уу?

Суумаар ч санагдах шиг. Өглөөнөөс хойш хэлэн дээрээ юм тавиагүй яваа. Гэтэл ээжийнх нь өгсөн идэх юм чемоданд нь байгаа. Галт тэрэгний буудал орохоос яахав, тэнд очиж байж хэрхэхээ шийдэхээс.

Калининаар дайрч Москва ордог хэд хэдэн галт тэрэгний хуваарь байвч, тасалбарыг зөвхөн нөөц захиалгаар зардаг гэнэ. Калининаас шууд Москва явдаг цорын ганц галт тэрэг маргааш өглөөний найман цагт явна, тасалбарыг зургаан цагаас зарж эхлэнэ. Бас нэг урагшгүй зүйл тохиов: Буудлын ресторан засвартай, энд юмхан амхарчих газар алга. Тээшийн газраас чемоданаа авч, ээжийнхээ өгсөн юмыг гаргаж авах уу? Тэгнэ гэхээр чинь чемоданыхаа түгжээг бүр эвдэх хэрэг болно, буцаагаад хадгаламжинд авахгүй, өглөө болтол чирч явалтай нь биш.

Саша Зөвлөлтийн гудамж руу гарлаа. Калинин өдөр аятайхан санагдаж байсан ч танихгүй хотоор харанхуй болсон хойно ганцаараа сэлгүүцнэ гэдэг нэг л зэвүүн.

Тэгтэл “Кафе-гуанз” гэсэн хаяг нүдэнд туслаа. Согтуу хөлчүү бус ердийн хүмүүс орж гарч байна, гэрэлтэй цонхны цаана ч олон хүн харагдаж байна. Хаалган дээр нь “9-19 цаг хүртэл ажиллана” гэж бичээстэй байна. Одоо зургаа болж байгаа юм чинь амжина гэсэн үг.

Саша орж гадуур хувцсаа тайлаад, дөрөв дөрвөн суудалтай олон ширээ шахцалдуулан тавьсан, нэлээд том танхим руу дотогшлов. Хөгжмийнхөнд зориулсан тавцан дээр хүртэл ширээ тавилчихсан харагдана, тэгэхээр дуу хөгжим энэ тэргүй ердийн гуанз байх нь, гэхдээ ундааны зүйл зардаг буфет тэртээ буланд байна, тэгээд “Кафе” нэртэй буй хэрэг.

Сул суудал алга, харин хаалганы ойролцоо ганц эзэнгүй сандал харагдав. Эхнэр, нөхөр бололтой, ядмагхан хувцасласан, ахимагхан хоёр сэхээтний дэргэд дунд эргэм насны, хөрзгөр хүйтэн царайтай, зангиа зүүсэн нэг эрэгтэй сууж байв. Масловагийн байранд байсан нөгөө цэрэг өмдөт шидэлтэй цаанаа л нэг төстэй, харваас шаралхуу солго. Нөгөөдөх нь манигар нүүртэй, гахай нүдтэй, энэ нь ясан шанаатай, нүдний шилтэй ч нэг үүлдрийн з а с а г л а г ч и д гэдэг нь андаш алга. Эрх мэдэл их, бага нь хамаагүй, гэм мэдэхээс зэм мэдэхгүй

засаглагчид.

Саша сандлын түшлэгнээс барьж,

-Сууж болох уу? гэв.

Авгай самгардан инээмсэглээд, нөхөр рүүгээ харахад цаадах нь,

-Суу, суу гэж хариулав.

Солго дуугарсангүй.

Саша суулаа.

Үйлчлэгч хүүхнүүд ширээн дээрээс сав суулгаа хураан, суудлын хоорондох давчуухан зайгаар гүйх нь халаг шуурхайлж байна. Ажил дуусах тийшээ ханджээ. Өлгүүрийн өвгөн хүн гарах тоолонд үүдээ түгжээд, хэнийг ч оруулахгүй байна. Сашагийн аз дайрчээ, арван минутаар оройтсон бол ийшээ орж чадахгүй болох байж.

Нэг үйлчлэгч ирж солгот хоёрдугаар хоолыг нь авчирч өгөв.

-Би нэгдүгээрхийгээ идэж гүйцээгүй байна, наадахаа аваад яв! гэж зөрөхийн аргагүй тушаасан янзтай зандрав.

-Гал тогоо яаруулаад байна гэж зөөгч хоолоо буцааж авалгүй тайван өчив.

Бордуу царайтай, хар үстэй, сэргэр хөхтэй, нуруу туруу цэх, бие хаа тэгшхэн бүсгүй юм. Бөлцгөрдүү гэхээр бор нүд нь гудиггүй хүйтэн харцтай гэмээр.

Саша руу жишүүхэн харж,

-Кафе хааж байна гэв.

-Би удахгүй ээ. Болвол, намайг хооллочихгүй юү.

Хүүхэн түүн рүү сонжих маягтай хормын төдий тогтосхийн харснаа харандаа, дэвтрээ зэхэж,

-Нэгдүгээр хоолноос байцааны шөл, гурилтай тахианы шөл хоёр үлдсэн, хоёрдугаарх нь гоймонтой бөөрөнхий мах.

-Байцааны шөл, бөөрөнхий мах хоёр авья. Компот юм уу, жимсний зутан байвал сайн байна.

-Талх хар уу, цагаан уу?

-Хар.

-Юм уух уу?

-Уух ий... А-аан... Үгүй ээ, баярлалаа...

-Бидний тооцоог бодож өгнө үү гэж авгай хүслээ.

Үйлчлэгч дэвгэртээ тоо бодоод дүнг нь хэлэв.

Эрэгтэй түрийвчээ гаргаж, мөнгөө төллөө.в

Үйлчлэгч дэвгэр, харандаагаа цагаан хормогчныхоо халаасанд хийгээд касс руу явав.

Хоёр хөгшин компотоо гүйцээж уугаад босцгоов. Авгай нь таягтай юмсанж, Саша руу эелдэгхэн инээвхийлэв.

-За, сайхан зооглоорой, баяртай гэж нөхөр нь өгүүлэв.

-Баяртай, та бүхний үйлс бүтэг гэж Саша хариулав.

Нөгөө солготой тэр хоёр баяртай энэ тэр гэсэнгүй. Өөрийг нь ирэхээс өмнө энэ муу солго хоёр хөгшинд бүдүүлэг авирлаж дүвчиг-нэсэн байх нь, тэгээд авгайн харцанд айдас хурчихсан, инээмсэглэж ядаж байж, тэгээд тэднүүс зөвхөн өөрт нь найрсаг хандаж байж гэж Саша бодов.

Хуучин бүтээлэгтэй ширээний голд цаасан цэцэгтэй бумба,

түүнийг тойруулж тавьсан өндөр хөлтэй дөрвөн жүнз, дөрвөн хундага байна.

Солго шөлөө идчихээд, тавгаа түлхэхдээ нэг жүнзийг шүргүүлж, тэр нь унаад хагарчихав. мань хүн нэг ярвайн тамшаалчихаад юу ч болоогүй мэт хоёрдугаар хоолоо идэж гарав.

Үйлчлэгч сав суулгаа хураах гэж ирээд жүнз хагарсныг үзмэгц, тэр хоёр руу асуусан харцаар харлаа.

Солго хоёр хөгшний сандал руу зааж,

-Тэднүүс хагалчихна лээ гэв.

Үйлчлэгч эргэн харсан боловч өлгүүрийн хавьд нэг ч хүн алга.

-Янзын улс шүү хэмээн Тэрээр толгой сэгсрэв. -Одоо надаас л суутгана.

Солго жишим ч үгүй хоолоо идэх аж.

-Та үүнийг шудрага явдал гэж үзэж байна уу? гэж Саша асуув.

-Юу гэнэ ээ, юу? хэмээн солго сэрдхийв.

-Таны хагалсан жүнзний үнийг үйлчлэгч төлөхийг та шудрага явдал гэж үзэж байна уу? гэж би асуусан юм.

-Дэмий балай чалчихаа боль гэж солго хоолоо идэх зуур хариулав.

Үйлчлэгч тэр хоёрын яахыг харзнан зогсов.

-Энэ жүнзийг та хагалсан шүү дээ гээд Саша солгын албаны шижээргүй царайг жигшин харав.

-Дахин хэлье: Балай юм чалчихаа боль, битгий хэрүүл өдөөд бай.

Сашад хэрүүл шиг хэрэггүй юм байхгүйг өөрөө ойлголгүй яахав. Гэтэл түүнд хурсан хамаг гомдол, түүний амссан хамаг басамжлал доромжлол энэ түшмэлийн ширмэн царайд, энэ эрээ цээргүй дураараа загнах авирт биелэлээ олсон санагдав. Энэ муу албаны шаар т э н д х и й х. Энэ бол хүн ардыг хайр найргүй тээрэмдэж, тэднийг зовоож, мөрдөж мөшгиж, доромжилж байгаа машины эрэг шураг. Тэгээд ямар ч ял зэмгүй өнгөрөхийг нь яана. Гэхдээ энэ мууг зүгээр өнгөрөөхгүй, энэ муу жолдоно. Саша тавгийг нь зайлуулж, урагшаа тонгойж байгаад,

-Чи муу зовлого, энэ хүүхэн чиний өмнөөс төлнө гэж бодоо юу? Чам шиг муу албины багалзуурт одоо энэ шилийг зооно доо, эхээ тэгмэрийг... гэж шазуур зуун занав.

Солго айсандаа гэдэсхийснээ, тэр даруй сэхээ аван төв болж,

-Та зүй бус хараал хэлж байна... Олон нийтийн газар... гээд үйлчлэгч рүү зааж, -Та гэрч болно шүү гэв.

-Гэрч болох ий?! Энэ хүн биш, таныг бузар зохисгүй юм хэлж байхыг чихээрээ сонссон шүү гэж хүүхэн хэнэг ч үгүй өчив.

Солго ийш тийшээ харвал үйлчлэгчид тэртээ булангийн хэдэн ширээний бүтээлгийг хуулж, өлгүүрийн тэнд сүүлчийн хүмүүс хувцсаа өмсөж байна.

-Жүнз ямар үнэтэй вэ? гэж Саша асуув.

-Таван рубль гээд үйлчлэгч инээмсэглэв. Инээмсэглэсэн чинь царай нь хөөрхөн болоод ирэв.

Бөөн бүтээлэг хумьж тэвэрсэн нэг бүдүүн үйлчлэгч авгай түүний хажууд зогтусан,

-Людка, наана чинь юу болоов? гэж асуув.

-Энэ нэг иргэн жүнз хагалчихаад, үнийг нь төлөхгүй гээд байна.

-Тэгвэл цагдаа дуудчих, ирж акт тогтоог.

Цагдаа, акт энэ тэр л Сашад дутаж гэнэ дээ. Гэтэл цагдаа ирүүлэхийг солго ч бас хүсэхгүй байгаа бололтой.

-Минийх хэдэв?

Үйлчлэгч тооцоолж, дүнг нь хэлэв.

-Үзүүлээтэх!

Хүүхэн цаасаа өгөв.

Солго шалгаж үзчихээд, тооцооны хуудсыг ширээ рүү шидэж, араас нь хоолныхоо мөнгийг хаяснаа, таван рубль дээр нь нэмээд, босч өлгүүр рүү зүглэв.

Үйлчлэгч ширээн дээрх юмыг хураах зуур дахин инээмсэглэв.

-Та хүний хоолыг гүйцээж идүүлсэнгүй.

-Үхэв л гэж дээ гэж Саша хариулав.

-Тайван хоолло, яарах юмгүй.

Үйлчлэгч Саша руу дахин жишүүхэн харснаа, гэнэтхэн,

-Чиний нэр хэн бэ? гэж асуув.

-Саша.

-Миний нэр Люда. Одоо хоёрдугаар хоолыг чинь аваад ирье.

Төдөлгүй хоёр тавагтай ирж ширээн дээр тавилаа.

-Саша, би бас чамтай цуг хооллоё, дургүйцэхгүй биз?

-Өө, хаанаас даа, харин ч баярлах байна.

Хүүхэн суулаа.

-Явуулынх юм уу даа?

-Яагаад тэгж бодоов?

-Чамайг энд ерөөсөө хараагүй юм байна.

-Тийм ээ, би явуулын хүн, Москвагаас явж байна.

-Томилолтоор явна уу, тэгвэл?

-Үгүй ээ, ажилд орох гэсэн юм, гэтэл таарч тохирох юм алга, буцах гэж байна.

-Москванд ажил хүрэлцдэггүй юм уу?

-Надад тэнд амьдрах газар байхгүй л дээ.

-Авгай, хүүхдүүд чинь?

-Авгайгаасаа салсан, хүүхэд байхгүй.

-Чи ямар мэргэжилтэй юм?

-Жолооч.

Тэрээр дахиад Саша руу хялайв.

-Хэзээ буцах юм?

-Өнөөдөр санаатай байсан чинь галт тэрэг дөнгөж маргааш өглөө явах юм байна.

-Тэгвэл, нууц биш бол, хаашаа явах вэ дээ?

-Рязань руу явах бодолтой.

Саша компотоо ууж дуусгаад, аягаа хажуу тийш тавив.

-Минийх хэдэв?

-Чи юу идлээ?.. Байцааны шөл, бөөрөнхий мах, компот... Рубль гуч.

Саша түрийвчээ гаргаж, хоолныхоо мөнгийг ширээн дээр тавив... Ээжийнх нь өгсөн дугтуйтай мөнгө нөгөө халаасанд нь байгаа.

-За, бол оо, чамд баярлалаа гэж Саша хэлэв.

-Хаашаа яараав? Галт тэрэг чинь өглөө шүү дээ. Хаана хонох санаатай байна?

-Галт тэрэгний буудал дээр.

-Тийм байж, юундаа яараав?

-Танайх чинь хааж байна шүү дээ.

Хүүхэн инээд алдав.

-Чи бид хоёрыг энд хаана л биз. Өглөө гаргачихна.

Тэрээр хоолоо гүйцээж идээд, тавгаа цааш нь түлхэснээ,

-Чи надад үнэнээ хэлсэн үү, эсвэл худлаа залсан уу? гэж ажил хэрэгч дүртэй асуув.

-Юуны тухай?

-Өөрийнхөө тухай.

-Итгэхгүй байна уу?

-Сэхээтэн хүн шиг хэрнээ шоронгийнхон шиг яриатай юм.

-Шоронгоос оргож гэж айгаа юу? Үгүй ээ, би хаанаас ч оргоогүй хэмээн Саша жуумалзсанаа, пиджакныхаа халаас руу алгадаж, -Паспорт, жолоочийн үнэмлэх хоёр аль, аль нь энд байна гэв.

-Намайг юуны учир өмөөрөв?

-хүний шаарыг үзэж чаддаггүй юм.

-Тэгвэл чи шудрага ёсны төлөө байгаа юм уу?

-Тийм, би шудрага ёсны төлөө байна гэж Саша үнэнхээсээ өгүүлэв.

Хүүхэн бодолхийснээ,

-Надтай нэрийн баярт очихгүй юү? гэж асуув.

-хэнийд?

-Миний найз бүсгүй дээр, Ганна гэдэг юм.

-Ганна... польш хүүхэн юм уу?

-Юун польш! Агафья байхгүй юү... Хөдөөнөөс хотод орж ирээд Гана болсон, хожим нь Ганна болчихсон, бүр аятайхан шүү дээ.

-Өнөөдөр юу болж байгаа юм?

-Нэрийн баяр гэж чамд хэллээ шүү дээ. Гэгээн Агафийн өдөр.

-хэн хэн тэднийд очихов?

-Зочид ирнэ, найз хүүхнүүд. Чамд ямар хамаа байна? Чи намайг дагаад очих юм чинь.

-Миний хувцсыг харж байгаа биз дээ. Юм хумаа тээш хадгалах газар өгчихсөн.

-Зүгээр, сайхан хувцасласан байна. Гоё байна! Буудлаас шөнө хөөж туудаг юм, үгүйдээн, дулаан газар жаахан суухгүй юү.

Явмааргүй санагдана. Гэтэл галт тэрэгний буудал дотроос хөөдөг бол хэцүү хэрэг шүү. Нээрэн, үгүйдээн, дулаан газар байзняя л даа.

-За яахав! Явцгаая.

Люда суудлаасаа босолгүй, үүд рүү толгой дожив:

-Гараад баруун тийшээ яв, хоёрдахь өнцөг дээр очоод, хөндлөн гудам руу эргэнгүүт, яг тэндээ намайг хүлээж бай.

Хүүхэн түүнийг хотын зах руу дагуулж ирэв. Харанхуй гудамжны мөс хөлдсөн усны цоргон дээр өнчин ганц чийдэн сүүтийнэ.

-Мэдээтэй яваарай, наана чинь хальгиргаатай байна, аль вэ, гараа.

Саша гараа өгсөнд хүүхэн бээлийгээ авлаа. Хүүхний гар дулаахан, өөрийнх нь хүйтэн байв.

-Осгочих нь уу?

-Үгүй ээ, дажгүй.

-Одоо хариугүй хүрээд ирлээ.

Тэр хоёр цас нь дагтаршсан зөрөг рүү эргэж, бин битүү хаалгатай дүлийрсэн модон хашааны хажуугаар, цагийн эрхэнд доош сууж газраас ургасан мэт харагдах ганц давхар байшингуудын дэргэдүүр явав. Хөшиг нь татаастай цонхнуудаас хаа нэгхэн зурвас гэрэл гологноно.

Нэг байшингийн дэргэд ирж, үүдний довжоон дээр гараад, Люда гараа зангидан хаалгыг нь цохив.

-Найрлаад, чихгүй болцгоочихож.

Дахиад цохилоо. Байшин дотор хаалганы чимээ гарснаа,

-хэн бэ? гэх хүүхдийн дуу гарав.

-Коля, би байна, Люда, онгойлго!

Арван тав орчим насны хөвүүн тэднийг пин рүү оруулж, хаалгаа оньсолчихоод, мэнд ус ч байхгүй, өрөө рүүгээ буцаж орлоо. Хаалга онгойход хормын төдийд ханан дээр гэрэл тусч, баахан дээл, пальто өлгүүрт буйг Саша харж амжив. Тэгтэл дахин гэрэл зурсхийж,

өрөөнөөс өндөр туранхай хүүхэн гарч ирэв.

-Люда, чи юү?

-Тийм.

-Коля гэж нэг ороолон, та нарыг харанхуйд орхичихож.

Хүүхэн гэрэлтэй гал тогооны хаалгыг онгойлгосонд, тэнд том вандан дээр керосин дэнлүү, баахан хувин сав харагдав.

-Тайчаад орцгоо.

-Удаан сууцгааж байна уу? гэж Люда асуув.

-Ам хуурай хэвээрээ байна гээд хүүхэн, халамцуу бололтой, инээд алдав. Людагаас нэлээд эгч, лав гучин тав орчим настай болов уу, уул нь бадриун царайтай юм шиг хэрнээ, нэлээн балгадаг байх, гундаж сэлхрэх янз оржээ.

-Орцгоогоорой!

Люда, Саша хоёр хүүхний араас намхан адартай өрөө рүү орлоо. Баахан лонх, идээ зууштай таваг тавилсан ширээг тойроод гурван эрэгтэй, нэг эмэгтэй сууж байна. Ээжтэйгээ нүгэлтэй адилхан, яг тийм ногоон нүдтэй, шовх хамартай, харин арай бараандуу үстэй Коля хэмээх нөгөө бандь нэг буланд нь суух аяджээ.

-Танилцацгаа, миний танил Саша гэж Люда нийт дунд зарлаад гэрийн эзэгтэйг түүнд танилцуулав:

-Энэ бол Ангелина Николаевна, сая үүдэнд харсан шүү дээ.

Ангелина Николаевна Сашатай гар барив.

-Энэ бол Иван Феокистович, гэрийн эзэн.

Буурал сууж яваа үстэй, ханхар булиа эр танилцсанаа илэрхийлж Саша руу товчхон харснаа, хажуугийнхаа хүнтэй яриагаа үргэлжлүүлэв.

-Нөгөө нэрийн өдрөө тэмдэглэж байгаа Ганна маань энэ, түүнд баяр хүрэг.

-Баяр хүргэе гээд Саша улаан хацартай, бандгар хүүхэнтэй гар барив.

-Глеб! Леонид!

Саша аль алин руу нь толгой дохьсон боловч Леонид нь түүнийг анзаарахгүй Иван Феокистовичтэй ярьсаар байв. Глеб гэж өргөн цээжтэй, бахим эр өөдөөс нь цагаан шүдээ яралзуулан найрсагаар инээмсэглэв.

-Танилцахад таатай байна.

Люда боодолтой юмаа задлаж Ганна руу сарвайв:

-Өмс дөө, баярын чинь бэлэг.

Ганна ширээнээс хөндийрч шаахайгаа тайлаад, шинийг өмсөж зогсогносноо, өрөөн дотуур явж үзэв.

-За ямар байна?

-Зүгээр ч юм шиг.

-За тэгвэл, наадхаа өмсөж, урт наслаж, удаан жаргаарай.

-За, Люда, Саша сууцгаа хэмээн Ангелина Николаевна тэднийг ширээ рүү урив.

Тэр хоёр урт сандлын наад үзүүрт чихэлдэн сууцгаахад, Люда яльгүй займарч, цаашаа ахсан дүр үзүүлээд,

-Эвлээд суугаарай гэв.

Саша жаахан ахиж, тийнхүү мань хоёр бөөрөөрөө нийлэн сууцгаав.

-Ууцгаа, идэцгээ, байгаа юм маань ширээн дээр байна... Хундага байна, хутга, сэрээ байна, таваг... Өө, таваг хаана байна? гэж Ангелина Николаевна үг дуу болов.

-Бид хоёрт дундаа нэг таваг болно гэж Люда өгүүлэв.

Сашагийн ойлголтоор бол тансаг ширээ засчээ: архи, улаан дарс, хиам, май загас, давсалсан өргөст хэмх, дарсан байцаа...

-Май загас авах уу? гэж Люда асуув.

-Болно шүү.

Люда загас, хэмх, байцаа энэ тэрээс тавгандаа хийгээд, архинаас хоёр том ногоон хундаганд дүүргэж, өөрийнхийгөө өргөөд, харчуулыг зандрах мэт,

-Харчуулаа дуугаа аядаарай! Гээд, -Баяраа хийж буй хүүхний төлөө ууцгаасан уу? гэж асуув.

-Хэлээд өгөх хүн байхгүй, чамайг л хүлээж байлаа, ялдам минь гээд Глеб инээмсэглэв. түүний дээд уруул жаахан татуу юм шиг болоод ч тэр үү, байнга инээмсэглэж байгаа царайтай, ер нь туж инээмсэглээд ч байгаа юм сан уу.

-Давтацгаая гэж Люда хэлэв.

-Давтацгаая гэж Глеб зөвшөөрөн, өрөөсөн гараараа хундгаа өргөж, нөгөө гараараа Ганнагийн бэлхүүсээр тэвэрч, -Аль вэ, чиний төлөө ууцгаая, Ганна-Ганечка, Агафьюшка, ялдам минь гэв.

-Чи болно шүү!

-Заллаа гээд Глеб хундагаа хөнтөрч ярвайснаа талх үнэрлэв.

Иван Феокистотвич, Леонид хоёр Ганна руу харах ч үгүй архиа ууцгаачихаад, яриагаа үргэлжлүүлэв.

Люда Ганнатай хундага тулгаснаа эргэж Саша руу хараад,

-Яагаад уухгүй байна гэв.

Саша уучихаад, май загасаар даруулав. Саяхан хооллосон учир юм идмээргүй байсан ч, гурван жил барааг нь хараагүй зуушийг үзээд, аманд нь юу юугүй шүлс хураад иржээ.

Люда хундагаа хөнтөрчихөөд, нүдээ анин толгойгоо сэгсрэв.

-Эхнийх нь шор, удаах нь шонхор, гурав дахь нь болжмор мэт болой.

Люда хоёр биендээ дахин хундагалаад, мөрөөрөө Сашаг нудран түүн рүү наалдав.

хэнтэй ч тулгаж барилгүй хоёрхон биеэрээ ууцгаав. Ер нь хэн

хүнгүй дор бүрдээ ууцгааж, зуушаа магтацгааж байв. Глебийн дуу хамгаас чанга хадаж, баруун солгойгүй ярианд оролцон, алиа хошин юм ярихын сацуу, Сашад талтай буйгаа илэрхийлэн түүн рүү байн байн өөриймсөг харна. Тэрээр зураач юм санж. Өөрийнх нь ярьж байгаагаар бол бүр нөгөө Акимовоор зураг заалгасан, Ленинград орж дамжаанд нь сууж байсан, тэр ч атугай, тэрхүү Николай Павлович түүнийг өөрийнхөө дэргэд, Ленинградад барьж байх санаатай асан, даанч Глеб өөр театрт орчихсон юм байж. Тэр театрынх нь уран сайхны удирдагч гэж урлагийн тухай ямар ч ойлголтгүй, будагны нэр ч мэддэггүй, хөх зосыг хар хөх будагтай, шар зосыг шунхтай андуурдаг арчаагүй мануухай байж!

Глеб одоо автобазад автобус буддаг гэнэ.

-Би чиний бүхээгийг хийхдээ л нэг хийнэ, ялдам минь. Калинин хотынхон цөмөөрөө шавж, нүдээ хужирлахаар юм хийж өгнө гэж Леонидэд тэрвээр илтгэв.

-Харж л байя гэж Леонид товч хариулав. Энэ бөгтөр хархүү Глебийн автобус буддаг баазын инженер гэнэ.

Мөн тэр баазад дарханы ажилтай Иван Феокистович,

-Хуучин юмаар шинэ юм босгоно гэж байхгүй хэмээв.

-Тэгэхгүй гээд яахав? Хотын захиргаа автобус шаардаад байдаг, чи хойш нь чангаагаад байдаг гээд Леонид таваг руугаа тонгойв.

-Үгүй ер өө, бийрээр хэд нялаад л болно гэж бодож байна уу? Үгүй шүү, ялдам минь гээд Глеб инээв.

Сашад Глеб нэг л дотно санагдав. Цайвар үстэй, цэнхэн нүдтэй, зөв хамартай, нүдэнд дулаахан царайтай, аргагүй л төв нутгийн орос доо. Дээд уруул нь яльгүй татуу нь бараг зохьсон гэлтэй, хэрвээ сахал тавьчихвал ерөөсөө анзаарагдахааргүй юм.

-Леонид Петрович, танайд жолооч хэрэгтэй юү? гэж Люда гэнэтхэн асуув.

-Хэрэгтэй байлгүй яахав.

-Сашаг авахгүй юү, энэ жолооч, Москвагийнх.

Леонид Саша руу тогтож харлаа. Өрөмдсөн харцтай, баргар царайтай, дуу цөөтэй Леонид уух тусам царай нь улам барайгаад байв.

-Үнэмлэх бий юү?

-Байлгүй яахав.

-Одоо байна уу?

-Байна.

-Үзүүл дээ!

Саша үнэмлэхээ сарвайв. Леонид түүнийг үзээд, буцааж өгөв.

-Долоон жил жолооч хийж байж, гуравдугаар зэргээсээ салдаггүй хүн юм аа.

-Салаад яахав... Би механикч байсан юм чинь.

-Тэгвэл манайд механикчаар орох уу?

-Үгүй ээ, баярлалаа, бусдын өмнөөс хариуцлага хүлээх хүсэл алга, жолооч л хийнэ.

-Хоёрдугаар зэрэгтэй байсан бол автобус өгч болох сон.

-Ачааных болно доо.

-Бааз руу яваад очоорой, ёсчилж өгөмз.

Чимээгүй нэг хундага дугтарчихаад Сашагаас цаашаа харав. Хэзээ очихоо асуувал зүгээрсэн. Хэрвээ маргааш гэж байгаа бол эндээ Калининд үлдэнэ, Рязань явах шаардлага алга. Автобаазад шууд ажилд орно гэдэг бол том аз. Хөлсний өрөө олоход Люда туслах байх. Гэтэл элдвийг шалгаах дур алга. Леонидын архи толгойдоо гарч байгаа нь илт байна, юу юугүй агсраад ирж мэднэ.

Харин Глеб бол согтох тусам сайхан зантай, дуулгавартай, наргиантай болж байна. Харин нүд нь жогтой гялалзаад байгааг бодвол жаахан дэгсдүүлэх, сайрхах дуртай бололтой. Акимовоор хичээл заалгах гэж Ленинград орсон гээд байгаа, гэтэл Акимов Арбатад, Вахтанговын театрт нэг жүжиг тавьсныг Саша санаж байна. Тэгэхээр Москвад ажилладаг гэсэн үг, гэтэл Глеб Ленинградад байдаг юм шиг ярьж байна. Залж байгаа хэрэг. Тэглээ ч гэсэн нүдэнд дулаахан, сэтгэлд дотно эр.

Энэ завсар дор бүрдээ ууцгааж суулаа. Ганна гал тогооноос чана-сан халуун төмс авчирлаа. Дарсан өргөст хэмхтэй нийлээд архины даруулганд зохиж байгаа гэж нүгэлтэй. Халамцаагүй хүн алга, Саша ч ялгаагүй.

-Та нар машиныхаа тухай ярьж болоо юм биш үү, та нар бол инженер, зураачид, би бол дархандаа л хайртай гэж Ангелина Николаевна хөлчүүрхэн хэлэв.

Тэгээд нөхрөө хүзүүгээр нь тэвэрч,

-Дархаан, чи надад хайртай юу? гэв.

-Байз л даа хэмээн Иван Феокистович гүндүүгүй өчив.

Гэвч цаадах нь салдаггүй:

-Ээ, дархан, миний дархан... Хэл л дээ, чи надад хайртай юу, дархаан?

Тэгснээ хариу хүлээж ядаад хүү рүүгээ харав:

-Колька, ороолон минь, явж унт, аль түрүүн хэлсэн биз дээ.

Гэвч Коля хээв нэг суусаар байв. Хүүхэд гэхээргүй хэрсүү царайтай тэр хүү томчуудын яриаг чимээгүй чагнан суух нь иймэрхүү наргианд төдийгүй, ээж нь амьтны нүдэн дээр нөхрөө тэврэх энэ тэрд дасчихсаны шинж. Энэ хүн түүний төрсөн эцэг биш гэдгийг Саша анх харахдаа л мэджээ.

-Хэд хэлэх юм бэ?

Коля байрнаасаа хөдөлсөнгүй.

-Колюшка, чи чинь яагаад ээжийнхээ үгэнд орохгүй байгаа

билээ? гэж Люда аргадах, шаардахын завсар хэлэв. Тэрээр Сашагийн мөрөн дээр гараа тохчихсон байгаа билээ.

Коля түүний хэлснийг бас тоосонгүй.

-Хэвтэж унт, Николай, тэгэхгүй бол маргааш унтаад сургуулиа тасалчихна гэж Иван Феокистивич хэлэв.

Тэгэнгүүт Коля сая босч, нөгөө өрөө рүү зүглэв. Үүдэнд очоод,

-Чи бага уумаар юм даа! гэж ээждээ гоморхов.

Ангелина Николаевна жуумалзах аядан,

-Сургамжилж байна! гээд толгойгоо сэжсэнээ, өөртөө, бас нөхөртөө архи хундгалаад, -Аль вэ, дархан минь, хоюулаа ууя, хорвоо дээр надад чамаас өөр хэн ч алга. Миний дарханы төлөө ууцгаая! гэв.

Бүгдээрээ ууцгаав. Люда, Саша хоёр ч уулаа.

Ингэхэд, энэ чинь, ямар гээчийн айл вэ? Жирийн дархан, огт жирийн бус хүүхэн хоёр. Энэ хүүхэдтэй хүүхэн “хуучуудын” нэг байх. Энэ хоёр юунаас болж ханилав? Нэг л ер бусын, үгүй ээ, одооныхоор бол ердийн болчихсон нэгэн хувь заяа мэдэгдээд байх шиг. Энэ байшин, энэ дархан хоёр Ангелина Николаевнагийн хувьд түүн шиг хүнийг няц илүүрддэг булнаас зайлуулсан ганц аврал нь бололтой. Тэр бул эр нөхрийг нь, ойр дотныхныг нь аль хэдийн сүнсгүй болтол нь тээрэмдэж, энэ хүүхэн жирийн ажилчин дархны ард орж аврагдаад, түүний овгоор овоглон, ийнхүү хүүтэйгээ хамт ард түмний гүнд бараа сураггүй болсон нь энэ байх нь. Ингэж аврагдсандаа дарханд сүсэглэн талархаж, чин сэтгэлээсээ хайрладаг бололтой. Саша энэ хүмүүстэй ийнхүү сууснаар шорон, цөллөгний өмнөх өнгөрсөн амьдралаараа шүргээд гарав гэлтэй. Энгийн, жирийн, ердийн хүмүүсийн дунд л эрх чөлөөгөө биечлэн мэдрэв. Ажил, сууц олох, оршин суух зөвшөөрөл авах энэ тэр гээд бэрхшээл, асуудал олон байгаа нь мэдээж. Гэхдээ, эдүгээ мань хүн, ямар ч ату-гай, эрх чөлөөтэй байна, золиг чамайг! түүнийг мөшгиж мөрдөхгүй, бичиг баримтыг нь шаардахгүй, хаанахын хэн болохыг шалгаахгүй байна. Людагийн танил, нэг хархүү л сууж байна, Людагаас өөр хэнд ч падгүй хархүү. Люда, мэдээж, өөр харчуултай эднийд ирж л байсан, өнөөдөр шинэ хүнтэй л ирээ биз. Тэгээд өнөө шөнө эндээ үлдээнэ. Өөрөө ч дургүйцэхгүй үлдэнэ. Варя байхгүй, Сибирийн ганцаардлаас үүдсэн зөгнөлт дүр л байж. Одоо өөрөө ямар ч утгаар, ямар ч зүйл ангиар бодсон эрх чөлөөт хүн. Оронд нь Люда байг л дээ, хорыг хороор, шарыг шараар гэдэг биз дээ. Тайгын замаар явган бэдэрч, буудал дээр суугаа хонож, галт тэргэнд чихэлдэж сар зовсоны эцэст дулаан хэвтэрт орох юм сан гэж үнэн голоосоо бодогдов. Ганц шөнө ч болохноо яахав дээ.

-Аль вэ, дуулцгаая гэж Ганна санал тавиад өөрөө шууд эхлэх нь тэр:

Хөгжилтэй дуунд сэтгэл цэнгэнэ,

Хөгжин дуулахад гуниг сарнина,

Хөдөө нутаг ч дуунд дуртай,

Хөлийн их хот ч дуунд дуртай.

Люда, Глеб хоёр түрэн авлаа:

Амьдрах, бүтээхэд дуу туслана,

Анд найз шиг дуудан дагуулна,

Дуутай хууртай амьдарч явахад

Дундрах ч үгүй, балрах ч үгүй дээ.

Глеб “дуутай хууртай”-гийн оронд “Шил юмтай амьдарч явахад” гэж маазруулав.

-Битгий саад хийгээч! гэж Ганна түүнийг зандрав.

-Сайхан дуу байна гэж Саша хэлэв.

Люда түүний мөрөн дээрээс гараа авч, нүд рүү нь эгцлэн харснаа,

-Чи чинь юу вэ, энэ дууг мэдэхгүй юм уу? гэж аяархан асуув.

-Мэдэхгүй.

Люда буруу харж хэсэг чимээгүй байснаа, дахин түүний нүд рүү харж,

-Мэдэхгүй юм бол дуугүй бай! гэж аяархан хэрнээ шазруун өгүүлэв.

Саша алдаагаа ойлголоо: Энэ дуу түүнийг цөллөгт байх үед гарсан байх нь, өөрөөс нь өөр энэ дууг мэдэхгүй хүн алга, ингээд өөрийгөө бариад өгчихөж. Люда хувцсаа засч байгаа дүрээр биеэ түүнээс хөндийрүүлээд, Ангелина Николаевнагаас оёдлын газар цуг ажиллаж байсан нэг хүүхнийх нь тухай асууж, Ганна ч тэр хоёрын ярианд ороод явчихлаа. Глеб, Леонид хоёр нэг нягтлан бодогчийн тухай ярилцаж байна. Глебт эсвэл мөнгө өгдөггүй, эсвэл их жаахан өгдөг нягтлан юм байж. Тэр хоёр үг сөрж магадгүй царайтай болоход, Иван Феокистович Леонидэд нэг юм хэлэв. Ширээний шуугианд болоод Саша юу хэлснийг ялгаж сонссонгүй. Ер нь чих тавиад ч байсан юм алга.

Бусдын адил “зөвлөлтийн жирийн хүн” шиг санагдаад байсан сэрэл нь үгүйрэн замхрах нь тэр. Үгүй ээ, бусдын адил биш юм! Онож хэлээгүй, буруу ганц үг л өөрийг нь барьж өгч байна, Глебтэй Акимовын тухай маргаагүй нь яамай даа. Гурван жил театр, кинонд ороогүй, шинэ дуу, шинэ ном битгий хэл, ямар шинэ машин гарсныг ч мэдэх юм алга. Амьдрал өөрчлөгдчихөөд байхад, яаж хоцорсныгоо харуулаад байж болохгүй. Хоцорсноо нөхтөл дуугүй байх юм уу, эсвэл аан уун гэсэн шиг аргалж байсан нь дээр.

-Гарах хэрэгцээ байна гээд Леонид босов.

-Би ч гэсэн хань болоход гэмгүй байх гээд Глеб араас нь дагав.

Тэр хоёр гарлаа.

Тэгэнгүүт Люда Ганнад уцаарлав:

-Чиний Тамарка бас л биднийг чадчихаж.

-Яаралтай ажил гараад захирал нь явуулсангүй.

-“Яаралтай ажил” гэдгийг мэднэ ээ... Тэр захирал чинь буйдан дээр, ширээн дээр гээд янз янзаар яаруулдаг гэнэ лээ гэж Люда улам бухимдав.

-За, боль доо, Людка, битгий уурла! гэж Ангелина Николаевна аргадав.

-Заавал ирэх ёстой шүү дээ, чадахгүй юм бол амлахын хэрэг юу байна!

-Цаадах чинь яаж ч чадаагүй л дээ. Дарга нар одоо шөнө ажилладаг болчихоод байна. Москвагаас шөнө л тушаал ирнэ.

-Юу гэж ирнэ гэж зүтгэсэн юм бэ.

Леонид, Глеб хоёр эргэж ирж, хүүхнүүдийн маргаан зогслоо. Люда ингэж бүдүүлэг авирлаж байгаа нь Сашад эвгүй байв. Сашад дургүй, тал өгөмгүй байгаагаа л тэр Тамарка гэгчээр шалтаглан харуулж байна. Өөрийг нь хасч, хайрч, бухимдаж байна.

Саша цагаа харлаа. Нэг хагас. Галт тэрэгний буудал яаж орох вэ, трамвай шөнө явахгүй нь лав.

-Яагаад цагаа хараад байна, ялдам минь гэж Глеб асуув.

-Би галт тэргэнд суух ёстой гэж Саша хариулав.

-Хаашаа явах нь вэ?

-Москва руу.

-Галт тэрэг наймд явна, амжина. Бид нар чамайг дөхүүлээд хаячихна. Леонид, чамайг авах машин хэзээ ирэхэв?

-Хоёр цагт ир гэж тушаасан.

-Сашаг дөхүүлж өгцгөөх үү?

Саша Леонидыг хүлгэлзэн харзнав. Ажилд оруулна гэснээ санах нь уу, үгүй юү? Санавал, “юуны чинь галт тэрэгний буудал, чи манайд ачааны машин барих болоо биз дээ” гэж хэлнэ.

-Дөхүүлж өгцгөөе.

Санасангүй. Тэгэхээр түүнд ямар ч жолоочийн хэрэг байхгүй, халамцчихаад л зүгээр цуурч байж. За яахав! Калинин бүтсэнгүй, Рязань явна даа.

Байшингаас нэлээн зайдуу бүрхүүлтэй ачааны “газик” зогсож байна. Аливаа гараашийн жижүүрийн машин.

-Эхлээд хаа хүрэх вэ, галт тэрэгний буудал уу? гэж Леонид асуув.

-Эхлээд намайг буулга гэж Люда тушаав.

-Зам их хазайна шүү дээ.

-Чамд хэцүү байна уу? Эсвэл бензин чинь хайран байна уу?

Леонид амандаа нэг юм үглэснээ бүхээгтээ суув.

Глеб хоёр гар дээрээ тулан, тэвш рүү үсэрч ороод, Люда, Ганна хоёрыг татаж гаргав. Тэр хоёр тэвш дагасан сандайлган дээр навсгасхийн сууцгааж, хамгийн сүүлд Саша машин дээр

гарлаа.

Ганна Глебийн мөрийг дэрлэн зүүрмэглэв. Эсвэл Людатай үг сөрөхгүйн тулд зүүрмэглэж байгаа дүр эсгэв.

Люда дүнсийгээд чимээ алга. Саша ч дуугарсангүй. Одоо яасан ч хамаа алга. Харанхуйд нүдээ аниад, юу ч бодохгүй явж байна.

Харанхуй хотоор баахан эргэлдсэний эцэст машин зогсов. Люда бүрхүүлийн арыг сөхөж ийш тийш харлаа.

-За, хүрээд ирж.

Тэрээр бослоо.

-Саша, надад туслаач.

Саша хөдөлсөнгүй.

-Хөөе, бууж эмэгтэй хүнд туслаач.

Саша машинаас үсрэн буугаад, Людаг гар дээрээ тосч авлаа.

-За, явцгаа! гэж Люда хашгирав.

Леонид бүхээгнийхээ хаалгаар цухуйж түүн рүү харав.

-Явцгаа, явцгаа! гэж Люда давтан хэлээд гараараа дохив.

Тэр хоёр нүүрэн талдаа олон харанхуй цонхтой хоёр давхар байшингийн дэргэд буусан байх аж. Люда хаалгаа татаж үзтэл түгжээтэй байв.

-Муусайн могойнууд! Намайг мэдээд зориуд түгжчихэж.

Тэрээр байшингийн дагуу явж очоод, нэг цонх руу тогшлов. Жаахан хүлээзнээд дахин тогшив. Гэрэл асч, хөшиг ярагдан, салхивчийг дотроос нь түлхээд,

-хэн бэ? гэх чавганцын хахир дуу хадав.

-Даша эгч ээ, би байна, Люда, хаалгаа тайл.

Салхивч хаагдаж, Люда буцаж орц руу ирэв. Гэрийн халаадтай, буурал үс нь сэгсийсэн, нойрмог эмгэн Люда, Саша хоёрыг оруулаад, тавхайгаа чирсээр өрөө рүүгээ оров.

Люда орцны хаалганы том дэгээг углачихаад, бүдэгхэн гэрэлтэй урт хонгилоор Сашаг дагуулан урагшлав. Хоёр талаасаа өрөөтэй аж. Хэзээ нэг цагт энд зочид буудал байсан нь илт. Гэхдээ тэр үед одооных шиг хаалга болгоны хажууд угаагуур өлгөж, дор нь сандал дээр түмпэн тосдоггүй байсан даа.

Люда хаалгаа түлхүүрдэн онгойлгож, босгон дээрээсээ зүтгэж унтраалгаа дараад, Саша руу толгой дохиж,

-Ор! гэв.

Хариугүй жижигхэн өрөө. Босоо шүүгээ, төмөр ор, ширээ, вандан, хоёр сандал, толь, хэдэн гэрэл зураг. Ингээд л гүйцээ.

-Тайчаач!

Сашагийн пальтог өөрийнхтэйгээ зэрэгцүүлэн өлгөж, алчуураа сандал руу шидчихээд, толинд харж үсээ илснээ, орон дээрээ сууж, Саша руу харлаа. Харц нь суунаглаад халамцуу нь илт.

-За, манайд ямар байна?

-Тохилог, дулаахан, сайхан байна.

-Хорихоос дээр байна уу?

-Хорих ямар хамаа байна?

-Чи чинь орчин үеийн дууг мэдэхгүй байсан шүү дээ. Ганц би анзаарсан нь яамай гэж бод, өөр хэн ч сонсоогүй, сонссон бол бүгд гадарлах байсан. Одоо чинь ард түмэн юмны учрыг ойлгоно ч, мэднэ ч.

-Хориход дуу дуулдаггүй юм уу?

-Тэгвэл шоронд.

-Одоо болох юм биш үү?

-Үгүй, тэгвэл ямар киноны дуу вэ, чи хэл л дээ?

-Ямар дуу?

-Ганнагийн дуулдаг дуу. “Хөгжүүн дуунд сэтгэл цэнгэнэ”.

-Мэдэхгүй.

-За тэр, чи бас кино ч мэдэхгүй юм байна. Эрхэм хүндэт хонгор минь, чи бол хорихынх.

-Би Умард хязгаарт ажиллаж байсан ч юм бил үү?

-Мөнгө хийгээ юү?

-Тэгж саная.

-Тэгээд их мөнгө хураав уу?

-Байгаа хэд маань миний л юм. Чамд зээлдүүлж болно шүү.

-Чиний мөнгө надад хэрэггүй. Намайг “медхен фюр аллес” (“тогооны алчуур”) гэж санаа юу?

-Герман хэлтэй байх нь. Чи юу гээд намайг байцаагаад байна гэж Саша тамшаалав.

-хэнтэй хэвтэрт орох гэж байгаагаа би мэдэх ёстой.

-Хөөе! Би чамаас зүүгдээд байна уу? Чи өөрөө л дарханыд дагуулж оччихоод, сая нааш нь чирч ирлээ. Би буудал руу явж байсан, чи яах гэж намайг машинаас буулгасан юм?

Люда чимээгүй азнаснаа,

-Дэмий юм ярьцгааж байна. Уусны гай гээд санаа алдан толгойгоо гудайв.

-Битгий ууж бай! Эндээс яаж буудал хүрэхэв?

-Гомдчих нь энэ үү? гэж Люда гудайсан чигээрээ асуув.

-Яасан гэж гомдох вэ? Зарим нь бүр овог ч асуухгүй шүү, гэтэл чи биеийн байцаалын бүх асуултыг алгассангүй.

-Биеийн байцаалтай, байцаалгүй би бүгдийг нь мэдэж байна. Хонгилоор явж байхдаа хараа биз дээ? Гурван хаалгыг лацдаад тамгалчихсан байгаа, үйлдвэрийн жирийн гурван ажилчныг

хүртэл аваад явчих юм. Чиний хорих газраас явааг би шууд ойлгосон, тэгж яривал бүр кафед байхдаа ойлгосон, тэгсэн хэрнээ чамайг гудамжинд орхиогүй, чамд үнэн санаанаасаа хандсан, гэтэл чи намайг доромжилж байна.

Саша сандал өнцөгдөн суув. Нойр хүрч байна гэж. Бүтэн хоног унтаагүй, нэмэрт нь балгачихсаныг хэлэх үү. Буудал л орох юмсан, тэгвэл тэнд дугхийчихнэ, бас галт тэргэнд зүүрмэглэчихнэ.

-Би чамайг доромжлоё гэсэнгүй, харин байцаалтаас залхаж гүйцээд байна. Би эрх чөлөөтэй хүн, май хар, паспорт энэ байна!

Тэрээр халаас руугаа гараа явуултал хүүхэн ухартусч,

-Хэрэггүй! Би чиний бичиг баримтыг шалгах гээгүй гэв.

-Үз, үз, үгүйдээн, овог мэдэж ав.

-Үгүй ээ, ав наадах аа.

-Үгүй бол үгүй л биз. Би цөллөгнөөс яваа нь үнэн, хугацаагаа дуусгасан, Москвад суух эрх байхгүй, ажилд орох санаатай наашаа ирсэн юм, гэтэл бүтсэнгүй, одоо өөр тийшээ явлаа.

Люда түүнээс хараа салгалгүй,

-Өөр тийшээ хаачих нь вэ? Леонид Петрович чамайг авна гэсэн, бэлэн ажил шүү дээ гэв.

-Надад эндшээ нэг л таагүй байна, та нар хэтэрхий сонор сэрэмжтэй юм.

-Хонгор минь, хаа сайгүй ийм байгаа, хаа сайгүй.

Тэгж хэлээд өвөр дээр нь сандайлж, толгойг нь тэвэрч аваад, уруулд нь наалдав. Саша түүнийг өргөж орон дээр нь тавилаа...

Өглөө нь түүнийг хүн татаж сэрээв. Хүүхэн пальто, түрийтэй шаахайгаа өмсчихсөн, инээмсэглээд зогсож байж.

-Найз нь явлаа, хоёрт ирнэ, би өнөөдөр хагас ажилладаг юм. Чи нойроо авч бай гээд тонгойн үнсэв. Ширээн дээр, тэр хар даа, талх, цөцгийн тос, бяслаг, хиам байна, цай халуун саванд байгаа. Жорлонд орох болвол, гарангуут, зөв тийшээ эргээд гуравдахь хаалга шүү, хэнээс ч айх хэрэггүй, шаарнууд ажилдаа явчихсан, орон дор тавхай байгаа, өрөөний түлхүүр ширээн дээр байна, дараа нь түгжээрэй, надад хоёрдахь түлхүүр бий. Хаалга цохивол хэнд ч битгий тайлж өгөөрэй. За баяртай, би явлаа.

Саша босч өмдөө өмсөөд, пиджакаа нөмрөн гарвал хонгилд хүн амьтангүй, нам гүм байна. Жорлонд орж, буцаж ирээд, үүдээ түгжин, түлхүүрээ ширээн дээр тавив. Угаагуурт гараа тосч шувтраад, босоогоороо хиам энэ тэрхэн амхарангаа хувцсаа тайлж, орондоо буцаж оров. Ор дэр гэдэг ямар сайхан юм бэ, солиг чинь! Тэгээд тэр даруй нойрондоо цохиулав.

Өрөөн дотуур хүн яваад байх шиг санагдаж, гэнэт сэрэв. Өндийн орон дээр сандайлвал зүрх нь жигтэйхэн дэлсэж байна. Цонхыг нь чулуугаар хага цохиод ч байх шиг ёозгүй зүүд зүүдлэжээ.

Люда халаад хэдэрчихсэн, ширээн дээр хоол унд зэхэж байв.

-Чамайг сэрээчихэв үү, хонгор минь? Хундага санамсаргүй харшуулчихлаа.

Саша суниав.

-Нойроо авчихлаа. Цаг хэд болж байна?

-Гурван цаг.

-Чи ирээд удаж байна уу?

-Дөчөөд минут.

Люда түүнийг үнслээ. Саша халаадных нь энгэрийг тайлж, тэвэрч аваад, тавихгүй нэг хэсэг зуурав...

-Чи намайг ноолж гүйцэх нь. Хөлөө даахгүй болох вий.

-Даах л болно.

-Бос, хонгор минь, хоюулаа юм идье, би хоол авчирсан, одоо халаачихья.

-Байз, би чинь, толгойгоо үсчинд угаалгачихсан, одоо усанд орох минь. Халуун ус эндээс хол уу? гэж Саша асуув.

-Ойрхон. Өнөөдөр даан ч эмэгтэйчүүдийн өдөр.

-Юу гэсэн үг вэ?

-Манай энд нэг өдөр эрэгтэйчүүд, нөгөө өдөр нь эмэгтэйчүүд ордог юм. Чи энд биеэ угаачих гээд Люда угаагуур руу заав. -Би бүлээхэн ус хийчихье. Би ингээд л угаачихдаг юм, халуун усны газар очдоггүй, тэнд балиар, юм хулгай хийнэ, завсар болгоноор нь салхи сийгнэ. Тэгээд орон дороосоо том түмпэн гаргаж алчуураар арчив.

Саша угаагуур, түмпэн хоёр руу харлаа.

-Би дотуур хувцсаа, майк, шуудаг, оймс энэ тэрээ солимоор байна, гэтэл чемодан буудал дээр, тээш хадгалах газар байгаа.

-Майк, шуудаг... яриад байх юм алга... Би одоо энүүхэн булангийн цаана их дэлгүүрт очоод аваад ирье, өвөл тэрүүн шиг элбэг юм байх биш. Чиний хэмжээ хэд вэ, дөчин найм уу, тавь уу?

-Мэдэхгүй.

-Тавь байх, тавийг авчихъя.

-За тэг, түрийвчнээс мөнгө ав гээд Саша пиджак руугаа заав.

Бүсгүй түрийвчийг гаргаж, гучин рубль авав.

-Энэ хүрнэ!

Тэрээр үүднийхээ жижигхэн шалавчийг угаагуур руу хөлөөрөө ойртуулж, дээр нь нөгөө түмпэнгээ тавиад, хажууд нь мухар сандал дээр нэг жижиг түмпэн, хөөснөг, саван энэ тэр зэхэв. Том данхтай халуун ус авчирч, угаагуур, жижиг түмпэн хоёрт хийгээд, шалан дээр шанагатай хүйтэн ус тавив.

-Том түмпэндээ зогсож байгаад жижигтэй усаараа булхаарай. Хүрэхгүй бол данханд ус байгаа. Алчуур энэ байна, миний халаад энэ байна, намайг майк, шуудаг авчиртал нөмөрч бай. Чамайг гаднаас нь түгжчихье, хонгилоор хүн амьтан холхиод эхэлчихэж, за би хувцаслачихлаа, бушуухан гүйгээд ирье.

Цоож торхийн хаалга түгжигдлээ.

Саша орноос босч, том түмпэнд орж зогсоод, хөөснөгөө савандан биеэ сайхан үрэв.

Ойрд усанд ороогүй, лав сар болсон байх. Гар, хоёр мөрөө үрчихээд, хөөснөгөө дахин савандав. Жижиг түмпэнтэй усаа аятайхан авч шалан дээр тавиад, мухар сандал дээр суув. Хөл, тавхайгаа үрэхэд ингэж суусан нь эвтэйхэн юм.

Мэдээж, халуун усны газартай яаж зүйрлэхэв, яаж Арбатын байрны онгоцтой жишихэв, тэглээ ч гэсэн дажгүй, ёстой догь байна.

Биеэ арчаад, Людагийн халаадыг нөмрөв. Халаад нарийхан ч гэсэн үстэй даавуу зөөлхөн, дулаахан оргиод вандан дээр ийнхүү завилан суухад мөн ч сайхан байна!

Одоо л хүнэрхүү болж байна, яарч бачимдан нэг галт тэрэгнээс нөгөө рүү гүйж харайлгах хэрэг алга, хулганан хярж элдэв юм санаанаасаа зохиох шаардлага алга. Хөдөө тосгонд биш, хот газрын цэвэрхэн тохилог өрөөнд ингээд сууж байна, аз ингэж гозойж байхад яахин баярлахгүй байх билээ? Люда чемоданыг нь буудлаас авчирья гэсэнгүй, тэгэхээр гэртээ удаан байлгах бодолгүй байх нь. Тэр нь ч зөв. Энэнээс илүү яахав. Жаахан ч болов амарч, бие нь тавирч, баривчилгаа, шорон, цөллөг, Ангар, Кежма, Тайшет толгойноос түр ч болов хөндийрлөө. Бас Варя ч бодогдохгүй, өөрийгөө хий зовоосон хардлага ч арилж, сэтгэл уужирсан байна. Москвагийн тухайд ч гойд гуньж гутрах юм алга, Москва өөрт нь хаалттай бол тэр л биз, ганц ээжээс нь өөр тэнд чарамхийх хүн ч байхгүй.

Бүтэшгүй санаагаар сэтгэл зогоох хэрэггүй, амь зуухын төлөө тэмцэл эхлэж байна, Калининд юмханаас зуураад үлдлээ ч, Рязань юм уу, өөр аль нэг газар руу явлаа ч, хаа ч амар хялбар байхгүй нь лав. Аз л мэднэ! Энэ Калининд аз дайрч, сайн санаат хүн таарлаа шүү дээ.

Люда эргэж ирээд, Саша руу боодолтой юм хаяв:

-Май, шуудагнуудаа бариад аваарай. Хар алга, хөхийг авчихсан шүү.

-Чамд хар нь зүгээр байдаг юм уу? гээд Саша инээмсэглэв.

-Үгүй, тээр...

Гадуур хувцсаа өлгөөд, түмпэн, данх, шанагаа гаргаж, шалавчаа хуйлаад, шалаа арчин тонгойход, банзал нь бэлхүүс рүү огшиж дээшлэв.

-Нааш ир дээ!

-Үгүй ээ, одоо хоюулаа хоолоо идэцгээе хэмээн Люда цэхрэн өгүүлэв.

-Би тэгсэн юм биш ээ гэж Саша заль гаргав. -Суу, би чамд нэг юм хэлье.

Хүүхэн суулаа.

-Хоолоо дараа больё. Би холбоон дээр очиж, Москва руу, ээж рүүгээ утасдах ёстой.

Люда хардах мэт нүдээ онийлгов:

-Ээж ий?

-Тийм ээ, ээждээ. Би өчигдөр амласан юм, миний утасдахыг хүлээж байгаа. Харин Леонид руу маргааш өглөө очъё. Намайг мартчихаагүй байгаа? Чи юу гэж бодож байна?

-Мартаагүй ээ, бүү санаа зов.

-Хөөе гэснээ Саша хүүхний гарыг илэв. -За яахав, эргэж ирээд ярилцъя. Дахиад нэг шөнө хонуулах уу?

-Тэгвэл чи миний нурууг авчих байлгүй.

-Энэ вандан дээр чинь хэвтээд өгнө.

Хүүхэн инээд алдав:

-Чи вандан дээрээс ч надад хүрэхдээ л нэг хүрнэ.

Москватай хоёрхон бүхээгнээс ярьдаг учраас нэлээд хүлээх хэрэгтэй болов. Цаг орчмын дараа холболоо.

Ээж нь түүний утасдахыг хүлээж байсан болохоор утсаа өөрөө авав. Саша хэрэг зориг бүтэмжтэй байгаа, нэг газар ажил амласан, бичиг цаасаа бүрдүүлэхээр маргааш тийшээ очно, тэр газар нийтийн байртай, тэр нь сэтгэлд таарахгүй бол өрөө олж хөлслөнө гэхчилэн ярилаа.

-Ээ, бурхны аврал, болж дээ. Сашенька, Варяд утасдаарай гэж ээж нь хэлэв.

-Яах гэж?

-Утасдаарай, надад хичнээн анхаарал халамж тавьж байсан билээ, би чамаас гуйя.

-Би сайн ойлгохгүй байна...

-Чи ойлгох болно. Саша, би гуйж байна шүү, утасд, аль болохоор эелдэг харьцаарай. Чи утсыг нь санаж байна уу?

-Яаж санахав.

-Бичээд ав.

-Надад цаас ч алга, мөр гаргах ч юм алга.

-Чи тогтоочихно, манайхтай адилхан, зөвхөн сүүлийн хоёр тоо нь л 44. Сашенька, заавал утасдана шүү, чи надад амлаж байгаа биз.

-За, чадвал утасдана, дахиад захиалга өгөх хэрэгтэй, энд их оочертой байна.

-Над руу хэзээ утасдах вэ?

-Гурав, дөрөв хоногийн дараа. Тэгэх үү? Чамд хэзээ бол эвтэйхэн байхав?

-Оройн цагаар, би зургаагаас хойш туж гэртээ байгаа.

-Зургаагаас өмнө бол?

-Би маргааш ажилдаа орно.

-Гэртээ зориуд туж суугаад байхын хэрэггүй, би бүтэн сайны орой утасдъя, за юу?

-За тэгье. Варяд чи утасдана шүү. Ээж нь үнсье.

-Утасдахыг бодно оо. Би ч үнсье.

Утсаа тавиад бүхээгнээс гарлаа. Захиалга авдаг цонхон дээр баахан хүн шаваастай харагдана.

Эхний хүн мөнгөө төлж, тасалбараа аваад,

-Хэр удаан хүлээх бол? гэж асуув.

-Хоёр цаг орчим. Дараачийнх нь!

-Завсраар нь албан газрууд орчихвол гурван цагаас наашгүй дээ гэж оочер дотроос нэг хүн өгүүлэв.

Хоёр, гурван цаг энд хүлээж юугаа хийхэв. Ер нь яах ч гэж тэгэхэв? Яарах юу байна? Варя ээжид нь их тус болсон, энэ тухай Саша мэдэж, үнэлж байгаа гэж Варяд ойлгуулах гэсэндээ тэр. Харахгүй юу, утасдаж байна, талархаж байна гэх ухаантай байх нь. Ээж нь өөрөө энэ тухайд их өөнтөгч, Варя ганц хань болдог хүн нь байх, гэтэл нөхрөөс салж барьж, зовж явна, тийм учраас өөрөө ч, Саша ч түүнийг дэмжих үүрэгтэй гэж бодож байх нь.

Тэглээ ч, тэглээ ч гэсэн... Варяг сануулсан нь дахиад зүрхийг нь зүсээд авах шиг болжээ. “Тэр одоо гэртээ байгаа”. Тэгэхээр ээжтэй нь аль хэдийн ярьчихсан, өөрийнх нь ирснийг мэдчихсэн хэрэг, утасдуулаарай гэж гуйсан байж магадгүй, эсвэл ээж нь сайн санасандаа, “Саша над руу утасдана, тэгэхээр нь чам руу утасдаарай гэж хэлнэ” гэсэн ч байж магадгүй.

Варягийн утас гэрийнхээ хаана байдаг нь Сашагийн санаанд орлоо. Тэгэнгүүт өөрийнх нь сургуульдаа буцаж орох болсныг тэмдэглэхээр Нинаг “Арбатын нүх” рүү урих гэж тэднийд бөөнөөрөө тавьж орцгоосноо саналаа. Нина эзгүй, Варя утсаар ярьж байж билээ. Утас нь гал тогооноос холгүй хонгилын хананд өлгөөтэй, оготор бошинзтой Варя ууцаараа хана налчихсан, өрөөсөн хөлөөрөө өвдгөө маажгаад зогсож байсан.

мань хүн тэгэхэд утсыг нь таслаад,

-Явцгаая! гэж билээ.

Варя түүн рүү гайхшран нүдээ бүлтийлгэсэн:

-Хаашаа?

-Наргия! Ялалтаа тэмдэглэе!

За, энэ бүхэн яамай. Дивангарын явдал. Варятай холбоотой бүх юм өөрийнх нь бодлын бүтээл, тийм учраас нэгэнт дууссан гэж өөрөө шийдсэн, өөрийгөө албадан шийдсэн. Толгой хоргодуулсан өөр хүүхэнтэй урьд шөнө унтсан, сэтгэл татсан хүүхэн.

Люда бүтээлэг нөмрөөд зүүрмэглэж байснаа, Сашаг орж ирэнгүүт, толгойгоо өндийн түүн рүү инээмсэглээд,

-Түгжчих! гэж хаалга руу дохив:

Саша оньсыг буулгачихаад, пальто, малгайгаа тайлав.

-Э-эх, жаахан ч болохноо амсхийлээ. Цаашаа харж бай, би хувцаслаатахъя.

Саша инээд алдав.

-Надаас бишүүрхэж байгаа юм уу?

-Яамай, дахиад бүтэн шөнө байна. Одоо оройн хоолоо идэцгээе, балгацгаая. Чи өлсчихөө байлгүй.

-Тиймэрхүү янз байна шүү.

-Хонгилд чамайг харсан хүн байхгүй биз?

-Байхгүй.

-За яамай. Цаашаа хар.

-Харахгүй бол яахав?

-Тэглээ гэж биеэс чинь бие ойчихгүй гээд Тэрээр нүцгэн гараараа орон доогуураа тэмтэрч улавч олоод,

-Май, гутлаа сольчих, тэгээд цаашаа харж бай гэв.

Саша вандан руу эргэв. түүний дээд хананд айл болгонд байдаг зурагнууд байна: эцэг, эх нь хүүхдүүдтэйгээ, эцэг, эх нь тусдаа, Люда ганцаараа, найз охидтойгоо, цэрэг хувцастай нэг эрэгтэй хүн...

-За, боллоо. Гараа угаа гэж Люда хэлэв.

Тэгээд ширээн дээр шил архи, хиам, бяслэг, талх гаргаж тавилаа.

-Кафегаас элэг авчирсан юм, одоо төмстэй халаачихъя.

-Чи бид хоёрт энэ байгаа чинь болно доо.

-Үгүй ээ, муудчихна. Би удахгүй.

Гал тогооноос хайруулын тавагтай элэг, төмсөө авчирч суугаад, хоёр хундаганд архи хийв.

-Чиний амжилтын төлөө.

Архиа ууцгаалаа.

-Гэрээр чинь юутай байна, ээж чинь яаж байна?

-Юмгүй ээ, бүх юм ёсоороо гэнэ.

-Санаа нь зовж байгаа даа.

-Зоволгүй яахав. Хөөе, Люда нэг ийм ажил байх юм, би түр паспорттой, байнгынхаар солих хэрэгтэй байна. Чи журмыг нь мэдэх үү? Эхлээд оршин суух зөвшөөрөл авч байж паспортоо солиулах уу, эсвэл эхлэж солиулчихаад зөвшөөрлөө авах уу?

Люда хоёрдахиа хундагалаж, өөрийнхийгөө уучихаад, хэрчим элгээр даруулснаа Сашаг ширтэн харав.

-Паспорт солиход чинь би туслана. Паспортын хэлтэст танил хүүхэн бий. Чи маргааш Леонид руу очиж бичиг цаасаа бүрдүүл, би өглөөгүүр тэр хүүхэн рүү очоод яадаг учиртайг мэдчихье.

-Юу л даа... Чамд тээр болох, мэдээж эвгүй... Гэхдээ...

-Би чамайг хөөгөө юү? хэмээн Люда үгийг нь тасдав. -Хэсэг зуур би тэвчье.

-Гэхдээ би маргааш автобааз дээр түр паспорттой очмооргүй байна. Хэрвээ сольж болдог бол, шууд байнгын паспорттай очсон нь дээр.

-За яахав, асууя.

-Чи тэр хүүхнээ сайн мэдэх үү?

-Нэг гарын улс.

-Надад цэвэрхэн паспорт шийтгээд өгөхгүй болов уу?

-Юу гэсэн үг вэ?

-Миний хар дансны тухай тэмдэглэл хийхгүй гэсэн үг.

-Мэдэхгүй юм. Ярилцах хэрэгтэй.

Тэрээр дахин нэг хундага ууснаа, учиртай нь аргагүй,

-Тэр хүүхэн паспортыг чинь элдэв чирэгдэлгүй солиод өгнө. Гэхдээ гар цайлгах хэрэгтэйг чи ойлгоно шүү дээ гэв.

-Хуулийн дагуу миний паспортыг солих ёстой.

-Хуулийн дагуу бол чи хоёр долоо хоног хөөцөлдөнө, дарга нарын үүдэнд ханатлаа сууна, чам шиг улс Калининд хичнээн бий гэж санаж байна? Ангелина Николаевнаг хараа биз дээ?

-Тэр яасан гэж?

-Яагаа ч үгүй. Харсан уу л гэж асууж байна. Харсан. Тэгээд л бол оо. түүний бүх юм ёсоороо байгаа. Иван Феокистовичтэй гэр бүлээ бүртгүүлж, түүний овгийг авсан. Тийм учрас би чамд, чам шиг улс Калининд вагон дүүрээд илүү гарна гэж хэлж байна. Москва, Ленинградынх ч байна, эндхийнх ч хангалттай байгаа. Тийм шүү. Тийм учраас хуулийн дагуу гэвэл хоёр долоо хоног нажидаа эдлэнэ. Наад зах нь тэр. Гэтэл чамд ганц өдөрт хийлгэж өгөх гэж байна. Тэмдэглэлийн тухай бол би мэдэхгүй. Хэрсүү хүүхэн байгаа юм, хуулийн дагуу бол янзлаад л өгнө, харин өөрийгөө хэрэгт хийхээр бол... Юу л бол.

Люда шаахайгаа сэгсэрч хаячихаад хөлөө Сашагийн өвдгөн дээр тавив. Саша түүний хөлийг илбэн таалав.

-Хөөе, хөөе, хол явж болохгүй шүү, гар чинь суначих вий гэж Люда сануулав. -Яасан гэж цөлөгдсөн болж байна?

-Яасны төлөө нь мэдээж шүү дээ. Яагаа ч үгүй л байхгүй юу.

-Улс төрийн учир уу? Ийм залуу хүнийг үү?

Саша инээв:

-Би насанд хүрсэн хүн.

Люда дахин бодлогоширсноо толгойгоо сэгсчив:

-За, тийм байж, хундагал. Бас гараа битгий сунгаад бай, чамд

хэлээ биз дээ. Би өдөрт ажил дээрээ хичнээн гүйдэг гэж бодож байна, тэгээд хөл бадайрчихдаг юм, гэртээ ирээд сандал дээр ингээд жийчихнэ шүү дээ. Гэтэл одоо тэр сандал дээр чи сууж байна. Тийм биз дээ? Хундагал!

-Ихдэх юм биш үү?

-Хундагал, өөртөө ч хий! Бас элгээ гүйцээж ид. Чи сайн идэж, хүч тамир суух хэрэгтэй.

Саша хундагалаж, хоюулаа ууцгаалаа. Люда ярвайсан боловч даруулах юм авсангүй.

-Чамд эцэг гэж байна уу?

-Эцэг, эх аль аль нь байна.

-Ах, эгч, дүү?

-Байхгүй.

-Айлын ганц хүү болох нь уу?

-Тийм болох нь.

-Эцэг, эх чинь сайн улс уу?

-Сайн улс.

Хүүхэн хөлөө өвдөг дээрээс нь буулгаж, улавчаа углан боссоноо, шүүгээ рүү бэгцэгнэж очоод нэг алчуур гаргаж нөмрөв.

-Жиндээд ч байх шиг.

Сууж бодлогоширсоноо, хундагаа цааш түлхэж,

-Би ч бас эцэгтэй байсан хүн хэмээн гэнэтхэн өгүүлэв. -Сайн эцэг. Усан зогсоолын токарчин байсан юм. Ээж маань бас ажилтай, талхан заводод, бас ахтай хүн, надаас хоёр ах. Би арван дөрвөн оных, ах арван хоёр оных, одоо цэргийн хүн болчихсон. Бас үеэл ах маань манайд байх, тэр бүүр таван оных. Аавын эгчийн хүүхэд, авга эгчийг нас барахаар манай хүн болсон юм. Одоо хэдтэй байх байж вэ? Гучин хоёртой. Яг тэгэх нь. Мэдээж, ганц өрөөнд амьдарцгаана, гэхдээ том өрөө, лав гучаад метр байх. Амар жимэр, сайхан аж төрцгөөж байлаа, хэрүүл уруулыг мэдэхгүй, бие биенээ хайрлан халамжлана. Ээж хоолоо хийчихээд, аавын ажлаасаа ирэхийг хүлээнэ, аавыг ирэнгүүт цөмөөрөө ширээгээ тойрон сууцгаана, мах байвал хүн болгонд тэнцүүхэн хуваана, эцэг хоолныхоо өмнө нэг жүнз архи ууна, дусал ч илүү уухгүй, ер нь архи уухгүй, хоёр ах ч уухгүй, архи уудаггүй хүмүүс байсан юм. Одоо би бүгдийнх нь өмнөөс уудаг юм гээд хүүхэн тачигнатал инээв. -Ганцаараа тэд нарын нормыг гүйцээж байна, надад хундагал. Хийгээтэх, би гадуур нь асгачихна.

Нэг балгалаа. Их согтож. Гэхдээ нэг хэлснээ үе үе давтахаас биш хэл нь ээдрэхгүй байна.

-Тийм учраас эцэг архи уухгүй, хоолныхоо өмнө л ганцхан хундага ууна. Хоолныхоо хажуугаар энэ тэрийг хөөрч, сайхан ярилцацгаана. Ээж юм л бол, чи амаа барьж бай, бусдын хэрэгт хошуу битгий дүрж бай гээд л эцэгт үглэх. Эцэг, юу л даа, ажлынхаа тухай ярьдаг юм, замбараагүй байдлын тухай, шудрага бус явдлын тухай энэ тэр. Эцэг тэр шудрага ёс гэдэг үгэнд их дуртай, тэгсээр байгаад шудрагалуулчихсан даа.

Тэрээр архинаасаа бас нэг амсав.

-Эцэг маань нуруу туруутай сайхан эр, ах бид хоёрт их хайртай, зээ дүү нь ч бас төрсөн хүү шиг нь л байх, бид хоёрын хувьд ч төрсөн ах гэсэн үг. түүнийг Иван гэх, аавын зээ дүү, миний үеэл ахыг тэр шүү дээ. Амралтын өдөр эцэг бидэнтэй амьтны хүрээлэнд очно, циркт дагуулж орно, эсвэл зүгээр гол руу юм уу, цэцэрлэгт цуг очиж зугаалцгаана. Би нэг удаа сахуу тусчихаад эмнэлэгт хэвтэж байлаа, тэгтэл аав нэг хилэн үстэй бүжин авчирч өгдөг юм байна, би жигтэйхэн хайртай болчихгүй юу, тэгсэн чинь эмнэлгээс гарахад нөгөөхийг чинь өгдөггүй, хэдэн будгийн харандааг маань ч өгдөггүй, эмнэлгээс юу ч гаргадаггүй номтой юм гэнэ, би баахан уйлаад. Ер санаанаас гардаггүй юм. Эцэг ч яахав дээ, үнэний төлөө, шудрага ёсны төлөө л үзэлцээд байх. “Шудрага ёс” гэж түүний гол үг.

Нэг удаа усан зогсоолын ажилчид манайд ирцгээж, хурал хийсэн тухайгаа, социалист уралдаанд үүрэг авсан тухайгаа энэ тэр ярьцгаалаа. Манайхан гавшгайчуулаа яаж шилж

гаргадгийг мэднэ биз дээ. Гэтэл эцэг нэр дэвшсэн нэг хүнийг шүүмжилсэн гэнэ, муу ажилтан ч гэсэн юм уу, хэн нэгний хамаатан ч гэсэн юм уу, ямар ч байсан шудрага биш гэж үзээд тэр тухайгаа хэлсэн юм байж, өөр хүмүүс ч хэлцгээсэн юм байж. Товчдоо, социалист уралдаан, гавшгайчдын асуудал хэлэлцсэн ажилчдын хурал тасалдуулсан хэрэг эцэгт наачих нь тэр. Нэг шөнө аваад явчихсан. хүн хашгирах дуунаар сэрсэн чинь ээж орь дуу тавьж байна. Өрөөг маань орвонгоор нь эргүүлж хаячихаад, аавыг аваад явсан, ээж дахин хашгирч халаглаад хонгилоор дэмий л араас нь дагасан, Петя бид хоёр усан нүдлэж, бас дагалаа, үеэл ах эзгүй, Ленинградад сурч байсан юм. За, тэгээд, дараа нь аймшигтай амьдрал эхлэх нь тэр. Хаашаа харахав, хэндээ хэлэхэв, дээгүүр танил тал, хамаатан садан байх биш, тааралдсан хүн болгон, “дуугүй л байцгаа, эс тэгвэл өөрснийг чинь шоронд хийчихнэ, эсвэл цөлчихнэ” гэх. Ээж маань зулгаа бартал яваад аавыг олоогүй. Бид нар Калинин даргад өргөдөл гаргасан, ээж прокурорт хичнээн ч очлоо доо, очсон газар болгон нь хөөхөөс өөр юм мэдэхгүй, тэгсэн чинь бас нөхөр нь баригдсан нэг авгай, тэд нар аавтай нэг дор ажилладаг байсан юм, удахгүй шүүх хурал болох гэнэ гэж ээжид хэлжээ. Тэд нарын шүүхийг мэднэ биз дээ, тусгай шүүх гээд гурван хүн, улайм цайм, усан зогсоолын байшинд хаалттай шүүсэн. Бид нар хашаан дотор нь хүлээцгээлээ, авгай хүүхдүүд нь шүү дээ, ээж, ах бид гурав бас байгаа. Долоон хүнийг ялласан юм байж, тэднийг арын хаалгаар аваад гарсан. Аав их тайван явж харагдсан, биднийг харангуутаа “Арван жил” гэж л амжиж дуугарсан. Өвөл цаг юм даг, хоёр сарын сүүлч бил үү, гурван сарын эх бил үү мартчихаж, аав эсгий гуталтай, гутал нь нэвт норчихвий гэж ээж голоош авчирсан юм байж, тэгээд надад бариулаад аав руу явуул-лаа. Би дөхөж очоод өгөх гэтэл харгалзагч түлхчих нь тэр, золтой л ойчсонгүй, аавыг минь голоошгүй эсгий гуталтай чигээр нь туугаад явчихсан. түүнээс хойш бараа ч байдаггүй, сураг ч байдаггүй, нөгөө шударга ёсныхоо төлөө эцэг маань баларсан нь тэр.

Люда хундагатайгаа дуустал уугаад Саша руу харав.

-Өчигдөр кафед яагаад чам руу очиж суув, яагаад чамайг Ганна-гийн нэрийн баяр руу дагуулж очив гэж чи бодож байна уу? Би тэр кафед хэнтэй ч танилцдаггүй, мэдэв үү. Тийм зар-чим-тай! хэнтэй ч. Зуу дахин сайхан эр байна уу, халаасанд нь алт чихээтэй байна уу, ёстой хамаагүй, хэнийг ч дагаж юм уу, дагуулж явж үзээгүй. Манайд гэр рүүгээ аваад явдаг сул энгэртэй хүүхнүүд, мэдээж, бий. Би бол заяа нь үгүй! Нүдээ ухаж өгчих гээд юм уу, элдвээр наалдах гэх амьтан алийг тэр гэхэв, харин би бол хэнийг ч хавьтуулахгүй, би бол бүтэн нэр-тэй хүн, мэдэв үү. Би чамайг харахад соньхон, жинхэнэ эр хүн байна гэсэндээ дагуулж явсан юм биш, бас намайг өмөөрсөн ч гэж тэгсэн юм биш, чи, мэдээж, шудрага зан гаргах нь гаргасан, миний хувьд бол шудрага зан, гэтэл та хоёр түрүүнд нь муудалцчихсан юмсан уу, хэн мэдэхэв. Чи надад таалагдсан энэ тэр гэж хэлж болно, гэхдээ би кафед хүнтэй танилцдаггүй, ёстой тэгж ярихгүй, өршөөгөөрэй! Гэтэл чамайг “шудрага ёс” гэдэг үгийг хэлэнгүүт зүрх ширхийгээд явчихсан. Яг зүрх рүү хатгачих шиг болж, шудрага ёс гэж аавын ярьдаг байсан нь толгойд зурсхийх нь тэр. Нөгөө этгээдийг шоронгийн зүхлээр билэндэж гарахаар чинь жаахан эргэлзэж, эрүүгийн ялтан юм болов уу ч гэж, үнэндээ, бодсон. Уул нь би чамайг юун хүн болохыг чинь харах гэж цуг суусан юм л даа. Тэгээд арваадхан минут цуг суусан ч, чамтай ярихад аятайхан байсан. Чам шиг шудрага ёс гэдэг улс зовлонгоос салах биш, тэгээд ээжийнхээ тухай, авгайгаас салсан тухай, ажил хайж байгаа тухай үнэнээ хэлж байна гэж би бодсон. Тэгж бодоод итгэ-чихгүй юу, ш у д р а г а хүнд итгэх гэсэндээ тэр, тэгээд чамайг дагуулж явсан юм.

-Дараа нь тэгээд ухаан алдчихсан уу? гээд Саша инээв.

-Хэзээ тэрэв?

-Яагаав, намайг дуу мэдэхгүй гэхээр.

-Өө... Нээрэн, хорихоос яваа юм байна гэж шууд ойлгосон шүү. Тэгэхээр надад худлаа хэлсэн хэрэг. Гэхдээ гэр рүүгээ дөхөөд ирэхийн үес өөр юм бодлоо: Одоо өөрийнхөө тухай хэн үнэнээ хэлж байгаа билээ? хэн ч хэлэхгүй, хэн хүнгүй ямар нэг юм нууж л байгаа. Гэтэл чи одоо ингээд явчихвал дахиад хэзээ ч уулзахгүй гэж бодогдлоо. Магадгүй, тэнд аавтай минь, ахтай минь уулзаж таарч явсан ч юм бил үү гэж бодохгүй юу.

-Ах чинь бас яасан юм бэ?

-Юу-уу... Эцгийг шийтгэнгүүт бид хэн болохов? “Ардын дайсны гэр бүл”. Тийм болцгоосон. Их юм үзсэн... Яриад барах юм биш. Үеэл ах маань тэгэхэд Ленинградад, далайн цэргийн академид ч гэл үү, би мэдэхгүй, товчдоо, цэргийн дарга ч юм уу, усан онгоцны ахмад ч юм уу болох гэж сурч байсан юм. Овог нь өөр, гэхдээ нагац ах нь ардын дайсан болж шүүгдсэнийг биеийн байцаалдаа бичээгүй юм уу, эсвэл бичсэн ч юм уу, өөрөө намын гишүүн, үзэл санаандаа учиргүй үнэнч, тэгээд намыг мэхлэж болохгүй, намдаа үнэнээ хэлж байх ёстой гэж туж номлоно. Тийм учраас Михаил манай эцгийн тухай ярьсан байж ч болно, ямар ч атугай, түүнд гар хүрээгүй, цэргийнхээ академид сурсаар байсан. түүний нэг найз нь мужийн намын хороонд байх. Тэгтэл Кировыг алсны дараа тэр найз нь түүнд Сталины үгийг ярьж. Сталин, “Та нар Кировыг хамгаалж байж чадаагүй, та нараар түүнийг оршуулуулахгүй” гэж хэлсэн гэх. Михаил энэ тухай сонсогчиддоо ярьсан юм байж. Маргааш нь мань хүн яадгаа алдчихсан амьтан гэртээ ирж, авгайдаа, “Намын хорооны товчоон дээр дуудаж, нөхөр Сталины тийм тийм үгийн тухай чи ярьсан юм уу гэж байна. Би: “Тийм ээ, ярьсан” гэлээ. Тэгсэн чинь “хэнээс дуулсан юм бэ?” гэж байна. Хэлвэл мужийн намын хорооны найз маань балрана гэдгийг тэр даруй ойлголоо. Тэгээд дуугарсангүй, нөгөөдүүл шахаад байна. Тэр өрөөнд нь ДЯАК-ын нэг хүн сууж байгааг хэлэх үү. Сүүлдээ, чи энэ үгийг нөхөр Сталинаас өөрөөс нь сонсоо юу? гэж тулгаж байна. Үгүй ээ, би нөхөр Сталиныг насандаа үзээгүй гэлээ. Тэгвэл чамд хэн нэгэн хүн тэр үгсийг дамжуулсан байх нь, тэр чинь хэн бэ? гээд салдаггүй. Санахгүй байна, хотоор тийм яриа яваад байна шүү дээ гэж хэллээ. Нэг харахнаа нөгөө яамны хүн намын дарга руу гар дохиж байна. Тэгэнгүүт цаадах нь, “Зөвлөлтийн эсрэг цуурхал тараасан, намд үнэнээ хэлээгүйн учир намаас хөөсүгэй” хэмээн шууд зарлалаа. Намын батлахаа хураалга! Би батлахаа өглөө. Дээр нь нэмээд, “Академиас халах тухай асуудлыг тавьсугай” гэж байна. Тийм учраас намайг маргааш академиас хална” гэж ярьжээ. Авгай нь, мэдээж, бөөн уйлаан майлаан болж. Юу юугүй төрөх гэж байсан залуухан хүүхэн. Тэр л бидэнд энэ тухай ярьсан юм. Михаилын нөгөө маргааш энэ тэр гэж юу байхав, тэр шөнө нь бариад явчихаж. Авгай нь хэд хоногийн дараа хөл хөнгөрсөн, төдөлгүй нярай биетэй, нялх хүүхэдтэй түүнийг цөллөгт явуулсан, одоо Казахстанд байгаа.

-Төрсөн ах чинь яасан бэ?

-Ах шууд дайчлагдаад Алс Дорнод руу явчихсан, одоо тэнд аж төрж байгаа, хаа нэгхэн захиа бичдэг юм. Ээжийг нас барахад би түүнд цахилгаан явуулсан чинь, оршуулга өнгөрснөөс тээр

хойно ирсэн, тэгээд надад мөнгө өгч, “Эндээс яв, эцгийн тухай, Михаилын тухай хаа ч бичиж дурдаж болохгүй, хэнд ч ярьж болохгүй” гэж хэлсэн. Гэтэл би, тэнэг толгой, чамд ярьчихлаа. Яагаад тэр вэ? Яагаад гэвэл, чи надад бас хамаг юмаа ярьсан. Би энэ бүхнийг сэтгэлээ бэтгэртэл өчнөөн жил хадгалж яваа юм, сая ярьчихсан чинь сэтгэл уужраад ирлээ. Дараа нь ахынхаа тушаасан ёсоор байраа энэ Калинин руу сольсон. Гучин метрын оронд энэ умгар хайрцгийг авсан юм. Ингээд зоргоороо аж төрж явна...

-Юу юу, энэ байшин хуучин зочид буудал уу?

-Чөтгөр л мэдэх байх. Зарим нь зочид буудал, зарим нь эмсийн хүрээлэн, зарим нь ажилчдын дотуур байр гэнэ. “Пролетарка”, “Вагжановка” гэдэг эндхийн хоёр фабрикийн ажилчдынх, хуучин Морозовын үйлдвэр. Тэр Морозов өөрөө хувьсгалч байсан, ажилчиддаа дотуур байр барьдаг байж.

-Тэр чинь хувьсгалч биш, харин хувьсгалд зориулж мөнгө хандивлаж байсан нь үнэн.

Хүүхэн гэнэтхэн нүдээ онийв:

-Миний ярьсан юмыг чи цуурчихгүй биз?

-Тэнэг юм бүү ярь.

-Ер нь ч, зөвлөлт засгийн эсрэг юу ч яриагүй шүү дээ.

-Дэмий донгосохоо боль!

-Зүгээр л яр-ил-цац-гаа-сан. Тэгээд л тэр... Ээжийн чинь нэр хэн бэ?

-Софья Александровна.

-Аавынх чинь?

-Павел Николаевич.

-Тэд нар чинь амьд уу?

-Амьд гэж чамд хэлсэн шүү дээ.

-Тэднийхээ амь насаар тангаргал, намайг барьж өгөхгүй гэдгээ тангаргал.

Сашаа жуумалзав.

-За яахав, тангараглая.

Хүүхэн гэнэтхэн цоо эрүүл нүдээр түүн рүү эгцлэн харав.

-Чамайг хэзээ ч барьж өгөхгүй гэдгээ би ч бас тангараглая. Чамд муу юм тохиовол надаас

болоогүй гэдгийг тогтоож ав.

-Чи яасан хачин юм ярьдаг юм бэ, Люда.

-Юу ярьж байгаага би мэдэж байна. Чи бол хаанаас ирсэн нь бүү мэд, харин би бол энд олон жил аж төрж байна, бүх юмыг мэднэ. Тийм шүү! Уул нь одоо Елизавета руу гүйж очоод ирвэл зүгээрсэн, би даанч согтчихож.

-Елизавета гэж хэн юм?

-Паспортын хүүхэн, чамд хэлсэн шүү дээ.

Тэр хүүхний нэрийг хэлээгүй л дээ, гэхдээ явж явж тэр ямар пад байхав. Саша юм хэлсэнгүй.

-Гэр рүү нь очвол зүгээрсэн, даан ч чи намайг согтоочихлоо.

-Би чамайг уу? Арай ч дээ?

-Согтоогоогүй юү? Тэгвэл наадахаа хундагал. Өглөө эрт, ажлаасаа өмнө тэднийхээр шүргэе, тэгэхгүй бол сэргийлэх дээр ярих эвгүй.

Шарль долоо хоногийн дараа цаг гаргаж Викаг “Каролина”-д аваачив. Ноён Эпштейн өөрөө үүдэнд тосч аваад, түрүүлж очиж зөөлөн сандал дөхүүлэв.

-Ноёд оо, сууцгаана уу! Сесиль одоохон сулрана, би түүнд хэлчихсэн, та нарыг хүлээж байгаа. Ийм ялдамхан авхайд хувцас хийж өгнө гэдэг бол Сесильд ёстой азны хэрэг гээд Тэрээр Вика руу мэххийж, -Хатагтай, та энд морилон ирсэн нь бидний хувьд их нэр төртэй хэрэг хэмээснээ Шарль руу бөхийн дуугаа намсгаж, хөөрхий амьтан мэт хоёр гараа дэлгээд - Хатагтай Плевицкая яг одоо морилоод байна. Уул нь таныг гэргийтэйгээ энэ цагт ирнэ гэж гэж би урьдчилан сануулсан юм л даа. Гэтэл жүжигчин гэдэг чинь жүжигчин, алдартан гэдэг чинь алдартан л байх юм чинь одоо яалтай билээ? Шууд л хүрээд ирэх юм... Би үнэхээр мөхөсдөж байна, Месье Шарль, үнэн шүү.

“Плевицкая, Плевицкая... танил нэр байна даа, жүжигчин Плевицкая” хэмээн Вика бодлогошров. Тэгснээ гэнэт саналаа, Москвад, тэдний гэрт хувьсгалын өмнөх үеийн пянзнууд байдаг билээ... Варя Панина, Надежда Плевицкая. Энэ Плевицкаяг тэднийд, Староконюшенныйд ирж байсан гэж эцэг нь ярьж байсан удаатай.

-Би танд бас нэг юм хэлье гэж Эпштейн дахин эхлэв.

Гэвч гүйцээж ярьж амжсангүй. Хувцас тааруулах өрөөний хөшиг нээгдэж, хүрмэн хантаазтай, тавь эргэм насны орос маягийн биерхүү хүүхэн гарч ирэв. Гялалзсан хар нүдтэй, том амтай, татаар гэлтэй шанаархаг дугуй царай нь шууд нүд татав.

Эпштейн Шарль, Вика хоёр руу,

-Pardon, monsieur, pardon, madame* гэгчхээд сайхь авгай руу харайлгав.

-О-оо, хатагтай Плевицкая. Танд...

*Уучлаарай, ноёнтоон, уучлаарай, хатагтай.

түүний амандаа бувтнахыг Вика сонсоё гэсэнгүй. Плевицкаягийн араас шар үстэй дэгжин хүүхэн гарч ирсэн нь, ээ базарваань, яах аргагүй Силька, Сесиль Шустер мөн дөө. Вика түүний арван зургаан настай охин байхыг санахаас биш, сүүлийн есөн жил үзээгүй ч гэсэн шууд таньжээ. Энд тааралдана гэж мэдэж байсан болоод таньсан байж ч магадгүй. Силька өөрийн биеэр байж байна... түүнийг тэдний ангийхан хөөрхөн охин гэж хэзээ ч үздэггүй байсан. Шингэхэн буржгар үстэй, учиргүй туранхай, гэхдээ гайхам тэгш галбиртай охин. Тэднийг есдүгээр ангид байхад мюзик-холл тоглож эхэлсэн, түүнд хүүхэд шалгаруулж авахад Сесилийг, ангийнхан нь Силька гэх, маш олон хүүхдийн дундаас “герлс” (охидын) бүлэгт оруулж билээ. Тэгээд ихэнх биеэ нүцгэлсэн герлсийн дунд тайзан дээр бүжиглэх болсон. Дараа нь хэрүүл шуугиан дэгдэж, мюзик-холлыг хааж, герлсийг хөөж тараасан. Сесилийг арайтай л сургуулиас хөөчихөөгүй, есдүгээр ангиа төгсөх боломж өгсөн, төгсөөд Сесиль

ээжтэйгээ Франц явчихсан болой.

Сесиль ч гэсэн Викаг есөн жил хараагүй, энд уулзана чинээ санаагүй аж. Аливаа үйлчлүүлэгчтэйгээ харьцдагаараа түүн рүү ялдамхан инээмсэглэв. Тэгэхүйд Вика цээжээ урагш түрсхийж,

-Силька, энэ чинь чи юу? гэж оросоор асуув.

Энэ орос хэл, хэн нэгнийг санагдуулах дуу, бүүр түүрхэн танил харц, бас тийм бүүр түүрхэн танил царай, хамгийн гол нь Силька гэж сургуулийнх нь нэрээр нэрлэсэн энэ тэр нийлээд гэнэт Москвагийнх нь амьдралыг санагдуулжээ. Сесиль Викаг танилаа. Тэгээд олзуурхаж сонирхох битгий хэл, ажирч хайхарсан шинжгүй,

-Тийм ээ, Вика, би мөн... Ямар тавилан бэ? гэж өгүүлэв.

-Би нөхөртэйгээ явна гээд Шарль руу дохив.

Шарль мэхсхийв.

Плевицкая оросоор ярихыг сонсоод эргэж, Викаг сонжин харав.

-Яахав, Силька, уулзсаных хоёр биенээ үнсэх үү? гэж Вика хэлэв.

Тэр хоёр үнсэлцэв.

-Чи огт хувираагүй байна шүү.

-Би хувираагүй, харин чи танхил, бандгар хойрго охин байв даа гэж Сесиль хариулав. -Одоо сайхан хүүхэн болж. Би эхэндээ чамайг таньсангүй шүү.

-Ямар сэтгэл хөдлөм учрал вэ хэмээн Плевицкая Вика руу хандаж, -Та Москвагаас ирээд удаж байна уу? гэв.

-Хэдэн сар болж байна.

Плевицкая Шарль руу харснаа францаар,

-Та нүд алдам гэргийтэй юм байна, месье... гэв.

Шарль хариуд нь төлөвхөн талархаад, явах болсны дохио болгож сандлаасаа босов.

Вика нөхрийнхөө янзгүй хариуг зөөллөх санаатай,

-Миний эцэг профессор Марасевич. Та Староконюшенныйд манайхаар ирж байсан гэж хэлэв.

Плевицкая нүдээ дүрлийлгэн, ихэд урамшиж,

-Өө, тэгэлгүй дээ... Тэнгэр минь... Староконюшенный хөндлөн гудам. Энэ чинь... Арбатад биз дээ гэв.

-Тийм.

-За, тэгэлгүй яахав... Бурхан минь, Арбат, Москва гэж.

Профессор Марасеевич, түүний Староконюшений байр энэ тэрийг Плевицкая санахгүй байгаа нь илт байв.

Хаалга нээгдэж, өндөр нуруутай, овор багатай ноёнтон орж ирэв. Нүдэн баримжаагаар бол гучин тав эргэм настай болов уу, алхаа гишгээ, толгойн суулт, нуруу цэх энэ тэрээс офицерийн жавхаа мэдэгдээд байх шиг.

Плевицкаягийн харцны байдлаар түүнийг нөхөр нь юм байна гэж Вика бодсоноо, насных нь зөрүүг гайхшран эргэлзэв.

-Миний нөхөр-генерал Скоблин гэж Плевицкая нөхрөө тэр хоёрт танилцуулаад, -Коля, чи бод доо, энэ ялдам залуу хатагтай Оросоос, Москвагаас ирээд дөнгөж хэдхэн сар болж байгаа юм байна гэв.

Скоблин эхлээд Шарль, Вика хоёр руу, дараа нь Эпштейн, Сесиль хоёр руу эелдэгхэн толгой дохиод, авгайгаа сугадан авлаа.

Плевицкая үүдэнд очоод, Вика руу эргэж,

-Та үнэхээр ялдам байна, охин минь. Бид дахиж таарна, эх болсон Москвагаа дурсана, ярилцана гэж найдаж байна гэв.

Вика зуны хоёр даашинз, хөнгөн костюм, түүндээ дүйлгэсэн цамц худалдаж авахаар болов.

Энэ бүхнийг Сесиль тэр хоёр зөндөөн удаан сонгов. Шарлийг ч нэг бус удаа дуудаж харуулж. Сесиль нарийсгах, хасах газар тэвнүү-рэн зүүгээр хатгаж, тавих тэлэх газар шохойгоор тэмдэглэж бишгүй удаан зууралдсан боловч Викагийн аж амьдрал, төлөвлөгөөний талаар юу ч асуусангүй, өөрийнхөө тухай ч юм ярьсангүй, ойртох бодолгүй байгаа нь тэр. Вика оросын ядмаг цагаачин биш, нөхөр нь нэртэй сэтгүүлч ч гэсэн, Сесиль тэднийг анх удаа харж байгаа юм чинь, хэр зэрэг бат гэр бүл болсныг хэн мэдэхэв, хэдэн сарын дараа гуйлга гуйгаад ч ирэх юм бил үү. Тийм учраас ойртох шалтаг алга. Үйлчлүүлэгчийн хувьд түүнийг үйлчлэхэд бэлэн, тэгээд л бол оо.

Вика энэ бүхнийг тодорхой мэдэрчээ. Нелли ч урьдаас сануулсан шүү дээ. Тэглээ ч гэсэн мань хүүхэн,

-Яаж ийгээд уулзаж, хуучлах юм уу гэжээ.

-Одоо хаврын улирал эхлэх гээд би маш их ажилтай, өглөөнөөс шөнө дөл хүртэл сууж байгаа. Гэхдээ би хэдэн минут олж, чам руу утасдахыг бодъё, чи утсаа надад өгчих.

Сесиль утасдахгүй гэдгийг ойлгож байсан хэрнээ Вика утасныхаа дугаарыг өгөв.

Викагийн худалдаж авсан захиалгат хувцас бүхий хоёр хайрцгийг “Каролина” пүүсийн зарлага хэд хоногийн дараа гэрт нь хүргэж ирэв.

Вика зарлагын гарыг цайлгаж явуулаад, шинэ хувцсаа өмсөж, сонжиж эхлэв. Үйлийн үргүй сайхан таарч. Парис гэж шал өөр юм даа! Москвад ийм даашинзтай ресторанд орох юм бол бүгд атаархаж үхнэ. Шарлийг орой ирэхэд, нөгөөдүүлээ ээлжлэн өмсөж үзүүлж, толины өмнө баахан эргэлдэв... Энэ үзвэр Шарль түүнийг толиных нь тэндээс олзолсноор өндөрлөжээ... Дараа нь энэ оройдоо дахиж хувцасны зүгийн юманд хавьтахыг зөвшөөрөөгүй. Мөн ч сайхан орой, мөн ч сайхан шөнө болов доо, хөөрхий.

Өглөө ундаа ууцгааж байхдаа Вика,

-Сесильд, үгүйдээн, утсаар ч болохноо талархал илэрхийлмээр байна. Чи юу гэж бодож байна? гэв.

-Манай энд тэгдэггүй юм. Ямар нэг юм засаж янзлах шаардлагатай бол утасдана. Гэхдээ та хоёр найзууд юм чинь, найзын хувьд утасдаж болно.

Вика хямсайсхийв.

-Бидний найз ч гэж юу байхав? Сургуульд үерхдэггүй байсан, сургуулиас хойш арван жил уулзсангүй.

Хоёр долоо хоногийн дараа Сесиль өөрөө утасдлаа.

-Вика, сайн байна уу, чи яаж шуу байна?

-Зүгээр, баярлалаа гэж Вика хайнгадуухан хариулав.

-Хүүш, Плевицкая хатагтай Гаво танхимд тоглох өөрийнхөө концертонд хоёр тасалбар ирүүлсэн байна. Очицгоох уу?

-Бодвол, тэр тасалбар чинь ноён Эпштейн та хоёрынх байлгүй.

-Үгүй ээ, чи бид хоёрынх. Зурвас цуг ирсэн. Надежда Васильевна намайг Москвагийнхаа хөөрхөн найз бүсгүйтэйгээ ирэхийг урьсан байна. Тэр найз нь чи гэдгийг зөвшөөрөх үү?

-За, за, цаасан малгайгаар яахав.

-түүний концертын тасалбар хэзээний л дуусчихсан байдаг юм, олж үзэхэд яггүй төвөгтэй.

Цагаачидтай танилцах албагүй, өөрийг нь хүнтэй битгий танилцуулаарай Сесилээс гуйчихна. Ийм сайхан саналаас татгалзана гэдэг бол тэнэг хэрэг.

-Гаво танхим чинь хаана байдаг юм бэ?

-Rue de la Boetie дээр.

Яаж явж хүрэхийг Тэрээр Викад зааж өглөө...

-Яг зургаа хагаст би чамайг орох хаалганы тэнд хүлээж байя.

Боломжийн үзэгчид. Зарим авхай нар үнэт эдлэл зүүжээ. Гэхдээ Сесиль хэнтэй ч мэндлэхгүй байхыг үзэхүл лав л түүний байнгын үйлчлүүлэгчид байхгүй юм байна гэж Вика дотроо дүгнэв.

Тэгэхээр нэг их чинээлэг үзэгчид биш, дээдсийн хүрээлэн биш байх нь. Гэхдээ хуучин Орост нэр цуутай хүмүүс энд байгаа нь

мэдээж, харин Сесиль тэднийг таньдаггүй бололтой.

-Чи сэтгэлийн жаргал эдлэнэ, ямар гайхалтай хоолойтой гээч хэмээн Сесиль өгүүлэв. - Намтар нь бас гайхалтай. Тариачин гаралтай, гуравдугаар ангийн боловсролтой, гэтэл хар даа, дэлхийн цуутан, ертөнцөөр явахгүй газар байхгүй, цагаачид түүнд амиа тавина. Харин, үнэнээ хэлэхэд, би дуучных нь хувьд түүнд хайртай, үйлчлүүлэгчийнх нь хувьд бол үгүй шүү. Олон ааштай, хатуу шаардлагатай, нэг зүтгэснээрээ зүтгэчихнэ, зөрөөд ёстой нэмэр байхгүй.

Аргагүй л ялгуусан концерт. Плевицкая тайзан дээр байгаа нь жинхэнэ орос ардын сайхан дуучин хүүхэн юм... Дуу болгоны дараа алга нижигнэнэ... Уйлж байгаа хүн ч аль овоо. “Хүдэн татсан Орос минь...”-ийг дуулахад Вика хүртэл тэссэнгүй мэлмэрүүлэв.

Нүдэн битүү шуурга гансран улиад,

Хүдэн татсан Орос минь цайвалзана.

Хайрам жаварт талын салхин

Харууслын ая өргөн сэлгүүцнэ...

Хараал идэж ханашгүй тэр хувьсгал гараагүй бол юу гэж хилийн чанад руу зулбаж явах билээ, аз жаргалтай аж төрөх жинхэнэ Орос орон тэр л байсан гэхээс Вика эдүгээ нэгэнт үгүй болсон хуучин Оросыг санагалзан гашуунаар сүүрс алдав.

Сесиль, Вика хоёр хажуугийн нэмэгдэл суудалд суусан ажээ. Концерт дуусахын өмнө тэдэн рүү нэг залуу ирж бөхийгөөд,

-Хатагтай Плевицкая концертын дараа та хоёрыг өрөөгөөрөө ороод гарахыг хүсч байна. Би дагуулж очно гэж шивнэв.

Концерт дууслаа. Үзэгчид тэр аяараа босчихсон алга нижигнүүлж байна. Эрэгтэйчүүд “Уухай!” хашгирцгааж байна. Плевицкая гараараа бараг шал шүргэн хэдэнтээ мэхийн ёслолоо. Үзэгчид тайз руу зүтгэлэн, цэцэг шидэлж байна.

Нөгөө залуу ирж, Вика, Сесиль хоёрыг учир нь олодохгүй хоосон хонгилоор нааш цааш дагуулан явсаар, Плевицкаягийн нүүр заслын өрөөнд оруулж өгөв.

Тэрээр хаалтны цаана өмсгөлөө сольж байв.

-Сесиль, Вика та хоёр орцгоо, би одоо бэлэн болно.

“Тавин гуравтай хүн ч аргагүй дээ (Плевицкаягийн насыг Сесиль түүнд хэлжээ), эмэгтэй хүмүүсээс хүртэл хаалтны ард нуугдаж байна” гэж Вика бодож амжив.

Плевицкая тансаг шар халаадтай гарч ирлээ. Том толины өмнө сууж, нүүрээ анхааралтай харснаа будгаа арилгаж эхлэв.

-Та хоёр сэтгэл ханав уу?

-Өө, яриа юу байхав гэж Сесиль, Вика хоёр нэгэн дугаар өгүүлэв.

Хонгилд хүмүүсийн дуу гарав...

-Миний даган баясагчид зүтгэлцгээж байна гэж Плевицкая будгаа арилгах зуур өгүүлэв. - Хүлээцгээж байг. Та хоёрыг энд байхад хүн битгий оруулаарай гээд би үүрэг өгчихсөн, тэгэх тусмаа би хувцсаа ч өмсөөгүй байна. Ер нь ч хүн амьтантай уулзмааргүй байна. Ядардаг боллоо. Дээхэн өдөр, орой хоёр дуулчихаад ер ядардаггүй сэн, гэтэл одоо ядраад байх болж. Тэглээ ч гэсэн дуулж байхдаа Оросын тухай л бодно, Орос орноо мартаж чадахгүй юм. Вика, хонгор минь, -таныг ингэж нэрлэж болох уу?

-Бололгүй яахав.

-Та надад Москвагийн тухай ярьж өгөх л дөө, Москвагийн тухай сонсох сон гэхээс яая даа гэмээр болох юм. Манайд, Озуар руу ир л дээ, цаг хүрэхгүй явах газар, Николай Владимирович машинаар очиж таныг аваад, орой буцаагаад хүргээд өгнө, хоюул ярьж хөөрч, хамт хооллоцгооё. Сесиль бардам бүсгүй, биднийг тоодоггүй юм, тийм учраас түүнийг урихгүй байна.

-Надежда Васильевна, та яасан зовмоор юм бэ? Миний яаж ажилладгийг та мэднэ, надад чөлөөтэй ганц минут ч байхгүй.

-Мэдэлгүй яахав, хонгор минь, мэдээд л зэмлэхгүй байна. Чи бол ажил хэрэгч хүн, над шиг гар хумхигчтай цуг байх сонин биш хэмээн Плевицкая сайхан сэтгэлээр өгүүлэв. Тэрээр хацрынхаа улаан будгийг арилгачихаад уруулаа будаж байна. -Тийм учраас урихаа больсон. Харин Вика бол ирэх ёстой, Москвагаас саяхан ирсэн бие хүний үгийг сонсмоор байна. Энд олон хүн Москваг мартчихаад, Оросыг мартаж байна... Вика ирнэ биз дээ?

-Дуртай очно, харин би лхагва, бямба гаригт л чөлөөтэй байдаг юм.

-Тэрийг чинь бодолцоно оо. Урд өдөр нь би утасдана гээд Викад дэвтэр, харандаа өгөв. - Утасныхаа дугаарыг биччих, та загас, үхрийн мах хоёрын алинд илүү дуртайв дээ?

-Өө, юу гэсэн үг вэ, Надежда Васильевна, надад ялгаа байхгүй, таны идэхийг л би иднэ.

-Таныг сайхан хоолоор дайлахыг хичээнэ ээ.

Тэрээр үүд рүү эргээд,

-Жан! гэж дуудав.

Тэднийг дагуулж ирсэн залуу орж ирэв.

-Жан, энэ хоёр хатагтайг гаргаж өг... За, баяртай Вика, баяртай Сесиль... Үнсэхгүй ээ, будаг болгочихно... Вика, бид тохирсон шүү!

Сталин Ежовын мэдээллийг дахин уншив:

“Лондон хотноо хааныг ширээнд нь залах ёслолд нөхөр Тухачевскийг оролцох үеэр, германы тагнуулын албадын даалгавраар түүний амь насанд халдах гэж байгаа тухай мэдээг гадаадын итгэл бүрнээ хүлээх эх сурвалжаас бид өнөөдөр авлаа. Тэрхүү алан хядах үйлдлийг бэлтгэх дөрвөн хүнтэй (гурван герман, нэг польш) бүлэг байгуулагджээ. Алан хядах үйлдлийг олон улсын уршиг үүсгэх санаатай бэлтгэж байж болохыг уг эх сурвалж үгүйсгэхгүй байна. Нөхөр Тухачевскийн замд болон Лондонд байх хугацаанд түүний аюулгүй байдлыг баталгаатай хангах бололцоо бидэнд үгүй буйг харгалзан, нөхөр Тухачевскийн Лондон явахыг болиулах нь зүйтэй гэж үзэж байна. Хэлэлцэн болгоохыг хүсье”.

Энэ зохиомжийг ӨӨРӨӨ Ежовт хэлж өгч бичүүлсэн билээ. Юу гэвэл, Тухачевскийн германы эсрэг байр суурийг германыхан мэднэ, түүний Варшав руу цэрэг хөдөлгөж байсныг польшууд санаж байгаа. Ийм сэрэмжлүүлэг үнэмшилтэй сонсдож байна. Мэдээж, Тухачевский бол үнэмшихгүй. Ноднин түрүүчийн хааныг оршуулах ёслолд оролцож Лондон ороод, Берлинээр буцаж ирэхэд хэн ч түүнийг хөндөөгүй. Өөрийг нь тэр чигээрээ оргочихно гээд гадагш нь явуулахгүй байгааг Тухачевский ойлгоно, хүзүүнийх нь оосор чангараад байгааг харж байгаа, армийн командын бүрэлдэхүүнд халаа сэлгээ хийж буй нь санамсаргүй хэрэг биш гэдгийг ойлгож байгаа, түүнд үнэнч анги нэгтгэлүүдийн командлагчдыг хэн ч дэмжихгүй, түшиг тулгуур байхгүй шинэ газар руу шилжүүлж байгаа юм чинь. ТХ-ны хоёр-гуравдугаар сарын Бүгд хурал дээр цэргийн удирдах байгууллагын тухай Молотовын хэлсэн үгийг Тухачевский өөрийнхөө чихээр сонссон: “Хэрвээ улс ардын аж ахуйн бүх салбарт хорлон сүйтгэгчид байгаа бол зөвхөн тэнд байхгүй гэж бид төсөөлөөд байж болох уу. Тэгж төсөөлвөл утгагүй юм болно... Цэргийн хэргийг удирдах газар бол том асуудал, тэндхийн ажлыг одоо биш, арай хожуу шалгана, тэгэхдээ маш чанд шалгах болно”. Тухачевский ТХ-ны Бүгд хуралд сууж байсан, энэ бүхнийг сонссон, тэгээд армид цэвэрлэгээ хийх нь гэдгийг ойлгохын цаагуур ойгосон.

Бүгд хурлын дараагаар цэргийнхнийг баривчилж эхэлсэн, гэхдээ дээд зиндааныхыг бус, дунд эгнээнийхнээс шүүрч эхэлсэн, баривчлагдсан хүмүүс нь цөм Тухачевский, Якир, Уборевич гурвын аль нэгэнтэй ойрхон алба хашиж байсан офицерүүд. Энэ явдал бас Тухачевскийг сэрдхийлгэжээ. Ийм учраас шийдвэртэй бөгөөд түргэн хөдлөх хэрэгтэй. Нэг сарын дотор бүх юм дууссан байх ёстой. Тухачевскийг гэнэтхэн хормын төдийд үгүй хийх шалтаг Гитлер өгнө гэж Тэрээр найдсан билээ. Гэвч өгсөнгүй. Яая гэхэв, сурсан дадсан аргаараа л янзлахаас. Гитлерийн хариуг жич хүлээе.

Гитлер арга саам хийж байна. Бас тэдний хүмүүс ч арга саам хийж байна. Тэр нь манайд ашигтай байгаа. Гэвч хүмүүсийг сольчихож болно, тэгвэл тэдний арга саамнаас юу ч үлдэхгүй.

Гитлерийн арга саам ойлгомжтой. Орост заналхийлж байгаа хэрнээ, өөрөө болохоор Рейны бүс нутгийг эзлэхсэн байгаа юм. Тэглээ гээд юу ч болсонгүй. Англи, Франц хоёр амаа тас жимийж байна.

Гэтэл Гитлерийн арга саам түүнийг арга саам хийхээс өөр аргагүй болгож байна. Большевик намын түүхэнд Тэрээр анх удаа Франц, Испанийн социал-демократуудтай эвсэлдэж байна. Эвсэлдэх нь зөв. Энэ хоёр улсын социалист засгийн газрыг дэмжсэн нь тэр. Дэмжих нь зөв, түүний бодлого уян хатан бодлого юм чинь. Одоо Европт Зөвлөлтийн эсрэг нэгдмэл эвсэл үүсэхгүй, Герман, Франц хоёрын зөрчил шууд хурцдаад явчихсан. Ингэснээр Гитлер Зөвлөлт Холбоот Улстай ойртох шийдвэртэй алхам хийнэ гэх горьдлого нэмэгдэж байгаа юм.

Одоохондоо тийм алхам алга. Гитлер хүчирхэг засаг, нэгдмэл төвлөрсөн намыг бүрдүүлж байгууллаа, төгс шүтээний хувьд ард түмнээрээ өөрийгөө нягт хүрээлүүлээ, дайсныг үзэн ядах нэгдмэл үзэл санаагаар ард түмнээ жигүүрлэж өглөө. Дайсныг үзэн ядах үзэл санаа бүх нийтээрээ айдаст автах уур амьсгалыг бүрдүүлдэг учраас хамгийн хүчирхэг үзэл санаа. Гэтэл Гитлерийнх бол үндэсний үзэл санаа, тэр учраас эцсийн бүлэгт хэврэг үзэл. Ийм үзэл нь Гитлерийг Германаас гадуур дайсан хайхад хүргэнэ, дайн байлдаан руу түлхэнэ, Тэрээр Германы аминд халгаатай үүрдийн дайсан, “далай, тэнгисийн эзэн”-бардам зант Англитай, эх газар дээрх түүний холбоотон Францтай байлдах болно. Оросын хэрэг түүнд байхгүй. “Германы анжисны” тухай яриа бол хоосон цэцэрхэл, Герман бол аж үйлдвэрийн орон, анжис тэдний гол зэвсэг биш. Франц дагуул улсуудаараа Германыг хүрээлчихсэн учир тэр хоёр хэзээ ч амар жимэр зэрэгцэн оршиж байгаагүй. Дэлхийд ганцаараа ноёрхох санаа Гитлерийн сэтгэлийн мухарт, дэврүүн төлөвлөгөөнд нь байдаг юм аа гэж бодоход, тэр ЗСБНХУ руу довтлохоосоо өмнө Францыг буулгаж авах ёстой болно. Ард нь Франц байдгаараа байх юм бол түүний хөл, гар хүлээстэй гэсэн үг.

Дэлхийн дайнд зэхэж байгаа бол хүчирхэг армитай байх хэрэг-тэй. Гэтэл Гитлерийн командын бүрэлдэхүүн ямар билээ? Пруссийн хуучин офицерийн баг, сэхүүн зантай фон-баронтнууд, Гинденбург, Людендорф хоёрын хамтран зүтгэгч, пруссийн мулгуу генералууд. Жинхэнэ дайн эхлэмэгц Гитлерийг тэд олзлоно. Ийм хүмүүс юу гэж тэр муу дэвхрэгээр удирдуулахав, өөрснөө түүнийг “зайдан улирсан ахлагч” гэдэг юм чинь. Одоо хэр генералууд штаб дотроо стратегийн төлөвлөгөө боловсруулж, газрын зураг, цаастай ноцолдож байгаа учраас тэд нар Гитлерт аюулгүй. Харин корпус, дивизээ командлаад ирэхийн цагт, тэдний мэдэлд амьд арми, сайн зэвсэглэсэн, германчилсан сахилга дэгтэй, тушаалыг үг дуугүй биелүүлдэг олон сая цэрэг ороод ирсэн байхад тэд Гитлерийг хог дээр хаяна. Тусгай зориулалтын отряднууд түүнийг хамгаалж чадахгүй.

Гитлерт ганцхан гарц байна: Хуучин генералуудаа зайлуулж оронд нь чадварлаг, үнэнч хүмүүс тавих хэрэгтэй. мань хүн түүнд тийм боломж олгосон. Зөвлөлтийн болон германы цэргийн дарга нарын нууц холбооны тухай материалыг Ежовын хүмүүс түүний гарт атгуулсан. Гитлер Ремийг яасан билээ, одоо өөрийнхөө генералуудыг тэгчихээд, ӨӨРТ нь Тухачевскийн тухай сөрөг материал өгөх ёстой.

Гитлерээс чимээ алга. Найдвартай шугамаар холбоо тогтоосон, ажил явж байна гэж Ежов зүтгээд байгаа. Ежов түүнийг мэхлэж зүрхлэхгүй. Гэхдээ цаг яваад байна. Цэргийн хуйвалдаан хийх аливаа боломжийг үр хөврөл төдий байхад нь устгах ёстой. Улаан Армийн командын бүрэлдэхүүнийг дээрээс нь эхлэн халах хэрэгтэй. Хойш нь тавьж болохгүй. Тэдний цэрэг шөнө Кремлийг эзлээд авна, тэгээд түүнийг баривчилж тэр дор нь буудан ална гэсэн бодолтой орондоо орох ёсгүй. Ворошилов бол хамгаалалт биш, Ворошилов бол айж,

орон доогуур орох нялцгай амьтан. Цэргүүд сургуулилж, лагерлаж байх хооронд, зургаадугаар сараас оройтуулалгүй цэргийнхний учрыг олох хэрэгтэй. Цэргийнхэн сонор сэрэмжтэй байгаа. Бүгд хурал дээр Уборевич тэгэхээс тэгэх гэж Бухаринтай гар барьсан, гэтэл Якир Бухариныг буудаж алах санал тавьсан, энэ бол цэргийн толгойлогчдод ямар ч эв нэгдэл, нийтлэг үзэл бодол байхгүй гэж харуулах гэсэн санаа. Байгаа гэдгийг мань хүн мэдэлгүй яахав. Тухачевский, Якир, Уборевич гурав бол дуу хоолойгоо нийлүүлчихсэн бүлэг. Зургадугаар сар шүү, зургадугаар сараас хождуулж хэрхэвч болохгүй! Бэрхшээл юунд байна? Хэзээ ч гэмшиж үзээгүй, өөрснийгөө буруутгах зуршил байхгүй. Тэдний дундаас хуучин сөрөг хүчний гуравхан хүн олдсон: корпус командлагч Примаков, Путна, дивиз командлагч Шмидт. Энэ гурав өнгөрсөн жил баригдсан, тэднээс мэдүүлэг авах гэж зүдэрч байгаа, Зиновьев энэ тэр шиг халирхай сэхээтнүүд биш, цэргийн хаттай хүмүүс учраас тэр муу турсганууд мэдүүлэг өгөхгүй байгаа. Тэгэвч нугарахгүй хаачихав. Тэдний нүүрэн дээр өчнөөн шүүн таслах ажиллагаа боллоо. Тэднийг албадаж яриулах арга бий гэдгийг ойлгохгүй тэнэг толгойнууд биш биз дээ? Хэрэг хүлээх бол зайлшгүй, өөр зам байхгүй. Нугалж эхлэхээр үүнийг сайхан ойлгоно.

Тэглээ ч гэсэн найдвартай давхар баталгаа, жишээлбэл, нийтлэх юм уу, иш татаж болох хавгаст хэрэг, германы албан хуудастай, нэр овогтой, германы тамга тэмдэгтэй материал байвал юу нь илүүдэхэв, ард түмэн сайхан үнэмшинэ дээ. Ежовын ашиглаж буй сувгийг өөрөө мэднэ: Парист цагаач цагаантнууд, Берлинд SD-(Аюулаас хамгаалах алба)-ийн дарга Гейдрих. Улс төрийн Товчооны шийдвэрээр ЗХУ хориод онд Липецк, Зержинск, Москвагийн хаяа дүүрэг энэ тэрд цэргийн баазаа Германд ашиглуулах болсон тухай хэлэлцээрүүдийн ж и н х э н э эх хувиуд Германы Ерөнхий Штабт бий, тэдгээр баримт бичиг дээр Тухачевскийн жинхэнэ гарын үсэг байгаа. Өөр юу хэрэгтэй юм бэ?!

Гитлер одоо хэр юу ч өгөхгүй байна. Гейдрих, түүний ажилтнууд энэ ажилбарыг онцгойлж үзэхгүй байж мэднэ, харин Гитлер өөрөө тэгнэ гэж үү! Тухачевскийн Германы эсрэг үзлийг мэднэ, нэмэрт нь мань хүн түүнд германы цэргийн дээд тушаалтны дундах дайснуудаасаа салах боломж олгочихоод байна.

Ингэж алгуурлаж буйг юугаар тайлбарлах вэ?

Сталин Поскребышевыг дуудаж, референт Кунгуровыг өөр дээр нь ирүүлэхийг тушаав.

-Мэдлээ! гээд Поскребышев хаалга хаав.

Сталин цонх руу очиж, Зэвсгийн ордны нурамгар байшин руу хэсэг зуур харахад, бодолд нь Гитлер дахин орж ирэв.

Гитлерийн бодлогыг задлан шинжлэх явцад Тэрээр тэдний сэтгэлгээнд төс байгааг тогтоожээ. мань хүн Гитлерийн нүүдлийг олон удаа дотроо тооцоолж үзсэн, тэгтэл Гитлер яг түүний бодож байснаар л хийнэ. Тийм учраас энэ ажилбарыг Ежовт даалгахдаа Гитлер нүүдлийг хүлээж авна гэдэгт Тэрээр итгэл төгс байжээ. Яагаад өдий хүртэл үр дүн алга байна?

Мэдээж, Гитлер тэр хоёр олон зүйлээр төсгүй. Гитлер түс тас хүн. Уян хатан чанар, алсын

хараа дутмаг. Гэхдээ тэдэнд нийтлэг зүйл их бий. Хувь заяанд нь хүртэл бий. түүний нэгэн адил Гитлер гуталчны хүүхэд, хэдийгээр эцэг нь гуталчнаар удаагүй, сүүлдээ гаальчин болсон ч тэр хоёр яах аргагүй ард түмний гүнээс гаралтай хүмүүс. мань хүн-орос биш, Гитлер бас язгуурын герман биш, австри хүн. түүний нэгэн адил бие дааж боловсрол эзэмшсэн, түүний нэгэн адил залуудаа урлаг оролдож байсан: Гитлер-уран зургаар, мань хүн-яруу найргаар... Толгойд нь нэг бадаг орж ирэв:

Чандруу мэт газар хөсөр унагсад,

Цагийн мууд дарлал зовлон амсагсад

Мөнх цаст оргилоос ч өндөрт мандана

Мөр цагаан найдлагаар жигүүрлэнэ, мэдэж ав.

Гэнэхэн цагаан шүлэг, гэхдээ зөвлөлтийн яруу найрагчид нэг их дээр бичих биш. Гитлерийн бүтээл ч гэсэн Рафаэлийнхийг бараадахгүй биз.

түүний нэгэн адил Гитлер энгийн хувцаслана, аль аль нь авгай хүүхнээр гайхуулахгүй, хүүхнүүд бодлогод нь нөлөө эс үзүүлнэ. Яг ТҮҮН шиг Гитлер мөнгө эс сонирхоно. Жинхэнэ жолоодогчийн цорын ганц өмч бол эрх мэдэл. Ард түмэн жолоодогч нь эд мөнгө хөөцөлддөггүй, амин хувьд нь юу ч хэрэггүй хүн гэдгийг мэдэж байх ёстой. Гитлер жирийн хүмүүстэй зургаа авахуулна, түүнийг жирийн хүмүүст анхаарал халамжтай, өр нимгэн, сайхан сэтгэлээр ханддаг гэхчилэн үлгэр домог тарааж байна, энэ бол хөрөнгөтний парламентын илбүүрдэх органы нэг, гэхдээ өөрт нь аятайхан байдаг бол яахав, түүний хувийн хэрэг.

түүний нэгэн адил Гитлер цэргийн албанд тэнцээгүй. Гэхдээ мань хүн иргэний дайнд, Гитлер дэлхийн нэгдүгээр дайнд оролцсон. Яг ТҮҮН шиг Гитлер дэмий чалчдаг парламентийн ардчилал гэгчийг үзэн ядна. Гол нь тэр хоёр засаг барих нууцыг мэднэ, ард түмний сэтгэл зүй, жолоодогчийн үүрэг зорилгыг ижлээр ойлгоно. Ард түмэн өөрийнх нь өмнөөс жолоодогч толгойгоо зовоож, жолоодогч шийдэж байгаасай гэж хүсдэг... Ард түмний хээгүй философи энэ, мань хүн, Гитлер хоёр үүнийг чадамгай ашиглаж байгаа.

Гадаа бүрий бууж, борооны жишүү хэдэн дусал цонхны шилэн дээр буулаа. Сталин босч унтраалга руу очиж, гэрлээ асаагаад буцаж ширээндээ суув.

Гитлерийн тухай их бичдэг билээ. Гитлерийн өөрийнх нь бичсэн болон түүний тухай гарсан бүх зүйлийг орчуулж ӨӨРТ нь үзүүлж байхыг Тэрээр тушаасан юм. Гитлер айхтар зоргоороо хүн, ямар ч хүнийг, тэр дотроо маш авьяаслаг хүнийг хүртэл захирч чаддаг хэмээн нэгэн дуугаар бичицгээсэн байх аж. Энэ бол жам ёсны зүйл: засаг барих авьяас бол бусад аль ч авьяаснаас хүчирхэг. Гитлерийг яхир гэж бичиж байна. Тэгвэл Ленин ч бас түүнийг яхир гэдэг байсан. Ленин эндүүрсэн хэрэг, зорьсондоо хүрэх гэж зоригоо чан-галан, шургуу улайран зүтгэхийг хүмүүс яхирлаж байна гэж бишгүй эндүүрдэг юм. Гитлер-“ёс зүйн хэм хэмжээнээс гадуур байдаг, арга цээрлэдэггүй” гэсэн байна. Тэгвэл ямар улс төрч ёс зүйтэй, арга цээрлэдэг билээ? Тийм улс төрч гэж байхгүй. Бас Гитлерийг холбирхой гэсэн байна.

Магадгүй ээ, магадгүй... Гэхдээ бодлого нь туйлбартай, чиглэсэн зорилготой байгаа. Аливаа улс төрчийн адил Гитлер арга саам хийнэ, олон хүнд ойлгомжгүй, учир зүйд нийцэхгүй, санамсаргүй алхмууд хийнэ, хүмүүс үүнийг нь холбирхой зан гэж үзэх жишээтэй. Үг хэлэхдээ ард түмэнд зулгуйддаг гэж бичиж байна. Жинхэнэ удирдагч бол өөрийг нь хэдхэн сэхээтэн биш, ард түмэн нь бүгдээрээ ойлгоосой гэж хүсдэг, тийм учраас энгүүн, хялбархан, ойлгомжтой ярина. Харин ярих маяг бол хүн хүнийх өөр. Тэрээр зугуухан ярьдаг. Гитлер хашгирч хийрхэнэ. Троцкий ч гэсэн үг хэлэхдээ хичнээн хийрхдэг билээ дээ, тэгсэн хэрнээ гарамгай уран илтгэгч гэгдэж байсан!

Гитлерийг антикоммунист гэдэг. Тэгвэл, чухамдаа, антикомму-нист гэж юу юм бэ? Германы коммунистууд бол Гитлерийн эсрэг хүч, ажилчин ангид нөлөөлөхийн төлөө өрсөлдөгчид. Энэ бол тэдний дотоод хэрэг.

Харин улс хоорондын харилцаанд бол үзэл санаа биш, улсын эрх

ашиг ноёрхоно.

Энэ бүхнийг Гитлер маш сайн ойлгоно. Тэгсэн хэрнээ генералын багийн талаар мэдээлэл солилцье гэхгүй байна. Яагаад тэр вэ? түүнд туслахыг хүсэхгүй байна уу? Тийм байх ёсгүй. Тухачевский Германы дайсан юм чинь, түүнийг зайлуулах нь Гитлерийн сонир-холд нийцнэ.

За яахав. Гитлерийн байр суурийг цаг хугацаа тодруулна, бидэнтэй холбоо тогтоох ухаантай улс төрч мөн эсэх, түүнд итгэхэд найдвартай эсэхийг цаг хугацаа харуулна. Тэгж яривал, улс төрд хэнд ч итгэж болохгүй.

Ингэхээр, Тухачевскийг буруутгах ажлыг шалгарсан аргаараа бэлтгэх хэрэгтэй. Лондон явахыг хориглоно гэдэг бол Тухачевскийг шууд ил өдсөн хэрэг.

Ежовын мэдээллийн булан дээр Сталин хөх будгийн харан-даагаар: “УТТ-НЫ ГИШҮҮДЭД. Хэдий харамсалтай ч нөхөр Ежовын саналыг зөвшөөрөхөөс аргагүй болж байна. Өөр хүний нэр дэвшүүлэхийг нөхөр Ворошиловт санал болгох хэрэгтэй. И.Сталин” гэж цохов.

Тэрээр хонхныхоо товчлуурыг дарав.

Поскребышев орж ирлээ.

-Май хэмээн өөрийн цохсон Ежовын мэдээллийг түүн рүү сарвайв. -Улс төрийн Товчооны гишүүдэд дамжуулаарай.

Поскребышев ширээ рүү дөхөж очоод, цаасыг авлаа.

-Улс төрийн Товчооны тогтоол бэлтгээрэй. Алан хядах үйлдэл гарах аюул байгааг харгалзан нөхөр Тухачевскийн Лондон явах тухай шийдвэрийг хүчингүй болгох... Цааш нь: Лондонд нөхөр Орловыг явуулах тухай батлан хамгаалахын АК-ын саналыг батлах. Ворошилов энэ мэдээллийг Тухачевскийд үзүүлвэл зохино... За. Кунгуров энд байна уу? Зүйтэй. түүнийг дууд.

түүний нэг референт Кунгуров гэж пиджакан дотуураа эрээн хажлагатай украин цамц байнга өмсдөг, өмднийхөө шуумгийг савхин гутал руугаа даруулсан, сахлаа цэвэрхэн хуссан, бор нүдтэй, бадриун эр ном барьсаар орж ирэв.

-Суугаарай!

Түшмэлтэй төсгүй, энгийн төрхтэй энэ хархүү түүнд аятайхан санагддаг ажээ. Улаа бутарсан, хээгүй дугариг царайтай, тамгын газрынхнаас инээмсэглэж байдаг цорын ганц хүн. Бусад нь түүний дэргэд инээмсэглэнэ гэж байхгүй, гэтэл энэ Кунгуров инээмсэглэнэ, сайн санаж инээмсэглэнэ, түүнийг харж байгаадаа баярлаж, тэгж баярласнаа нууж чадахгүй байгаа нь тэр. Уриалгахан. түүний ямар ч даалгаврыг биелүүлэхэд бэлэн. Залуудаа цөллөгт байхдаа харж байсан Сибирийн залуустай төстэй. Хэдийгээр украин цамцнаас салдаггүй ч гэсэн овгоор нь бодвол сибирийнх юм уу, уралын хүн. түүнийг бишрэн харж, түүний үг болгоныг тогтоож, хөдлөх бүрийг бахдан сууна.

Бас нэг зүйл: Дөнгөж гуч гарсан хэрнээ Кунгуров таван хэл-англи, герман, франц, итали, испани-мэднэ. Ажилчин гаралтай жирийн хөвүүн, хуучин улаан цэрэг, ажилчны сургуулийн дараа их сургуульд орсон, тэгээд, хар л даа, таван хэл сурчихаж. Тийнхүү хэл сурах чадвар бол гагцхүү биологийн онцлог гэдгийг батласан, тийм онцлог зарим хүнд бий, заримд нь байхгүй.

Кунгуров өрнөдийн сонин сэтгүүлээс түүнд зориулсан товчлол бэлтгэнэ. Үндсэн мэдээллийг ТАСС өгнө, Кунгуров бол зөвхөн түүний биечлэн сонирхдог асуудлаар, зөвхөн түүнд зориулсан тойм бэлтгэнэ. Тэрээр одоо Гитлерийн намтар, үйл ажиллагааг судлаж байгаа, ямар нэг сонин баримт заавал олно, түүнд юу хэрэгтэйг яг таана. Хайна, уншина, орчуулна. Сайн ажиллана.

Кунгуров авчирсан номоо харуулав.

Нөхөр Сталин, би тун сая хэвлэх үйлдвэрээс ирлээ. Гэхдээ энэ номыг дахин уншиж амжсангүй. Маргааш илтгэхийг болгооно уу.

-Юун ном билээ?

-Гитлерийн энэ жил хэлсэн үгийн эмхтгэл.

-Та чинь германаар нь уншаад, бас орчуулсан шүү дээ. Маргааш гэж хойш тавих хэрэг юу байна?

-Би оросыг нь хянаж унших гэсэн юм, алдаа байж магадгүй.

-Наана чинь сонин юм байна уу?

-Янзын гэмээр юмнууд байна, ялангуяа энх тайвны тухай гээд Кунгуров инээмсэглэв. -Рейн мужийг эзлэснийхээ яг дараа Кельнийн жагсаал дээр хэлсэн үгэнд.

-Аль вэ, өг дөө!

Сталин гарчигнаас “Кельнийн жагсаал дээр хэлсэн үг”-ийг олоод, гүйлгэж харахаар нээх гэтэл ном нь огтлогдоогүй, хуудас нь битүү байв.

-Би огтолж амжаагүй юм гэж Кунгуров өгүүлэв. -Сая ирсэн чинь нөхөр Поскребышев тань руу яаралтай ир гэсэн зурвас ширээн дээр үлдээсэн байна.

Сталин номыг ширээн дээр дарж байгаад, нөгөө битүү хуудас руу хуруугаа оруулан арзайтал ураад уншиж эхлэв...

Тэгтэл гэнэтхэн “түгшүүрийн дохио” нь ёстой санаандгүй ажиллаад эхлэх нь тэр. Энэ бол өчүүхэн төдий аюул нүүрлэхэд агшин зуур мэдэрдэг, түүнээс хэзээ ч салдаггүй, түүнийг байнгын бэлэн байдалд байлгадаг сэрэл билээ. Энэ сэрэл нь хэзээ ч түүнийг хуурч байгаагүй, түүнийхээ ачаар сэрэмжлэх цохилт өрсөн хийж, өөрийгөө, амь насаа, албан тушаалаа хамгаалан авардаг амой.

Сталин Кунгуров руу хартал цаадах нь мэл гайхсан царайтай нөгөө урсан хуудас руу ширтэж байж. Цээрлэсэн ёозгүй харцаар ширтэж байж. Хуруугаараа урлаа гэж түүнийг буруушааж байх нь. **ӨӨРИЙГ** нь буруушааж зүрхлэж байна! Нэг муу номны сүгэндээ харуусч, харууссанаа нуух ч царай алга.

Харин мань хүн бол нууж чадна. Хэзээний чаддаг юм нь энэ. Сталин тэр даруй дургүйцлээ дарж, ном руугаа анхаарлаа төвлөрүүлээд, Гитлерийн Кельнд хэлсэн үгийг уншиж дуусгав.

“Бид энх тайвныг хүсч байгааг нотлох ямар ч хэрэгцээ байхгүй. Энх тайвны тухай ингэж ярьдаг, энх тайванд ингэж тэмүүлдэг, энх тайвны төлөө ингэж тэмцдэг надаас өөр хүн энэ дэлхий дээр бий гэдэгт би итгэхгүй байна... Би явган цэрэг явсны хувьд дайны хамаг аюулыг яс арьсаараа мэдэрсэн хүн. Олонхи хүн дайныг миний нүдээр харж байгаа гэдэгт би итгэл төгс байна... Тийм учраас тэд нар миний санаа бодлыг хүлээж авч байна. Би ард түмнийхээ эрх, эрх чөлөөг өмгөөлөн хамгаалж байна. Би энх тайвныг хүсч байна”.

-Лут луйварчин шүү гэж Сталин өгүүлэв.

-Тийм ээ, зүгээр ч үгүй, Рейн мужийг эзлэж авангуугаа ингэж хэлсэн байгаа юм гэж Кунгуров өчив.

Гэхдээ түүний харц нөгөө арзайтал урсан хуудаснаас салахгүй хэвээр байна. Үгүй, мөн эмзэглэв ээ, бас! Ямар цэмцгэр, яасан ёсорхуу эр вэ!

Сталин дахиад, гэхдээ энэ удаа бүр зориудаар эхний хуудаснаас аваад хуруугаараа тэгэхээс тэгэх гэж зугуухан урж эхлэв. Урчихаад жаахан гүйлгэж харна, дахиад урна, дахиад гүйлгэж харна, тийнхүү номын бүх хуудсыг урж салгав. Кунгуров энэ зуур түүний гарыг бараг яс нь шархиран харж буйг мэдэрч байвч, түүн рүү нэг ч харсангүй. Тэрээр номоо хамхиад, Кунгуровг өгөв.

-Хамгийн сонин гэхээр газруудыг нь тэмдэглээд нөхөр Поскребышевээр надад өгүүлээрэй.

-Мэдлээ.

Кунгуров гарлаа.

Сталин түүний араас харзнав. Одоо номоо янзалж, хайч баахан тачигнуулна даа.

Тэрээр босч, өрөөн дотуураа хэд алхав.

Кунгуровын харцнаас яагаад ингэтлээ хэрдхийв? Нэг муу номын донтон ч юм уу, өгөршсөн профессорыг бол ойлголгүй яахав. Гэтэл мань хүн ИЙ өөртөө татаж авсан, үхэр нохой мэт үнэнч гэж бодож байсан, ажилчны сургуулийн нэг муу гайхал ингэдэг байна! Номын хуудас салгасан төдийгөөс нөхөр Сталиныг сэтгэлдээ буруутгана гэнэ ээ! Нөхөр Сталин номтой харьцаж чаддаггүй байх нь, нөхөр Сталин ном үзээгүй, харанхуй бүдүүлэг амьтан байх нь гэж байгаа. Хутга гуйгаад хэрчиж болно, гэтэл ийм гэмт хэрэг үйлдлээ!

Тэрээр Кунгуров дээр алджээ! Цэмцгэр, ёсорхуу хүн биш, далд санаатай хүн байна. Хуурамч хүн. Хариугүй муу номны сүг түүнд нөхөр Сталин сайн байхаас үнэтэй юм гэнэ. Яг үнэнч нохойн нүдээр л хардаг байсан хүн дээ. Гэтэл мань хүн Кунгуровыг санаандгүй байхад нь гэнэдүүлээд түүн рүү харчихсан, тэгээд түүний царай инээмсэглэхээс өөр дүрд хувилдгийг нь яг харчихсан. Биширч байгаа царайлдаг нь тэгэхээр худлаа байх нь. Үг болгоныг нь, дохио зангаа бүрийг нь алдахгүй шүүрдэг нь үнэнчийнх биш, өөр нэгэн бодол санаатайнх юм байна. Ямар бодол санаа вэ? Нөхөр Сталиныг судлаж байна уу? Яах гэж судлаж байна? Түүхэнд зориулж уу? Өдрийн тэмдэглэл хөтлөдөг байх нь уу? Тэмдэглэдэг байх нь уу? Гэртээ харьчихаад, тэгээд тэмдэглэдэг байх нь уу? Тэгвэл өнөөдөр тэмдэглэнэ дээ... Нөхөр Сталин хутгаар зүсэхийн оронд хуруугаараа урж, номтой зэрлэг балмадаар харьцдаг гэх ухааны юм бичнэ. Улс орны жолоодогчийн хажууд ажиллаж байна, түүнтэй уулзаж, ярилцаж байна, нүдэн дээр нь түүх бүтэж байна. Яагаад тэмдэглэж болохгүй гэж, яагаад нөхөр Сталины өдөр бүрийг түүхэнд зориулан тэмдэглэж болохгүй байхав, тийм замаар яагаад өөрөө түүхэнд орж болохгүй билээ? Суут хүмүүсийн нөмөрт явдаг амьтад ингэх нь элбэг. Францын зохиолч Анатолий Франсын нарийн бичгийн даргын бичсэн жижигхэн ном Надяд байсныг нэг удаа өөрөө харсан... түүний нэрийг мартчихаж... Номных нь нэр юу билээ дээ? А-аа, тийм... “Шаахай, халаадтай Анатолий Франс”. Тэгдэг шиг санагдана. Хорон санаатай ном! Анатолий Франсын гэдэс дотрыг ёстой худалсан байна лээ.

Тэрээр энэ тухай олонтаа бодсон. Ялангуяа Бажанов дээр сох алдсанаасаа хойш. ӨӨРИЙНХ нь нарийн бичгийн дарга байсан түүнд бас л итгэж явсан. Дэмий итгэж байсан нь хожим тодорсон. Муу үхээнц нохой, хилийн чанад руу зулбаж алга болчихоод баахан бузар булай юм бичсэн, санаанаасаа зохиосон. Хуншгүй зан гаргасан. Он тооллын бичээч бол хүний долоон булчирхайг тоочих ёсгүй, он тооллын бичээч хожмын үр удмынханд зориулж зөвхөн и х ү й л с и й г л бичих ёстой. түүний хувийн амьдралыг гэрчлэх этгээд түүнд хэрэггүй.

Тэгвэл түүний хүрээллийнхнээс хэн нь гэрч болох гэж зүтгэлж байна? Мулгуу Поскребышев уу? Лав үгүй. Товстуха юу? Дэндүү ухаантай, дэндүү болгоомжтой нэгэн. Нөгөө Мехлис, Двинский энэ тэр болон түүний тамгын газрын бусад хэн боловч, түүнд ойрхон буйн хувьд ямар үүрэг хүлээснийгээ ойлгож байгаа. Тиймэрхүү өдрийн тэмдэглэл маягийн юм хөтлөвөл яаж дуусч мэдэхийг ойлгож байгаа. Энэ хориотой зүйл гэдгийг Улс төрийн Товчооны гишүүд

ч мэдэж байгаа. Гэтэл Кунгуров шиг, хэний ч анхааралд өртөхгүй, өчүүхэн албан хаагч бол тэмдэглэл хөтлөж чадна, түүнийг тийм юм хийж зүрхлэнэ гэж хэн ч сэжиглэхгүй. мань хүн Кунгуровын дэндүү сониуч харцыг түрүүн ч анзаардаг байсан. түүний хөдлөх бүрийг түүн шиг ажигладаг хүн байхгүй. мань хүн үүнийг өөрт нь үнэнчийнх гэж боддог байсан, гэтэл дөнгөж өнөөдөр өөр юм олж харлаа. Нөхөр Сталины тийм бүдүүлгийг олж мэдээд дотроо баясаж байна. Өдрийнхөө тэмдэглэлд бичих юмтай болж л дээ.

Сталин үүднийхээ өрөө рүү гарч, Паукерийг нэн даруй дуудахыг Поскребышевт тушаав.

Паукер амьсгаадсаар орж ирлээ. Дахиад л дүрэмт хувцсаа шинэчилчихэж. Яараад сольж амжсангүй, тэнэг толгой, гоёх дуртай баас...

-Кунгуровыг мэдэх үү?

-Мэднэ. Тамгын газрын референт.

-Яг өнөөдөр үүдэн дээр түүнийг нэгж, нийтийн шалгалт, маргааш бүх юмыг буцааж өгнө гэж хэлээрэй. түүнд юу л байна, ном, үнэмлэх, бичиг, тэмдэглэлийн дэвтэр, аливаа цаас, тамхи татдаг бол хайрцагтай тамхи, энгэрийн үзэг гээд бүгдийг нь хурааж ав. Тэгээд надад авчирч өгөөрэй. Кунгуровын араас нарийн ажиглалт тогтоо.

Кунгуровыг нэгжиж, олсон бүх юмаа Паукер нөхөр Сталины өрөөнд ширээн дээр нь дэлгэж тавив.

Сталин түүнийг үүднийхээ өрөө рүү гаргаад, үнэмлэх бичигнүүдийг үзэв. Бүгд цэв цэвэрхэн аж. Нөгөө Кунгуровын авчирч үзүүлсэн ном тэр чигээрээ байна. Сталин хуудаснуудыг эргүүлж үзсэн боловч, хавчуулсан юм алга, харин нөгөө арзгар урсныг танаад тэгшилчихэж. Юм нууж уу, үгүй юү гэж дугуу хайрцагтай тамхийг нь ширээн дээр асгав. Алга, нуусан юм байхгүй байна. Энгэрийн үзэгнийх нь толгойг авч шагайж харвал дотор нь бас юу ч алга. Кунгуровг ажлын дэвтэр байсангүй, харин нэг жижигхэн тэмдэглэлийн дэвтэр байж. Сталин түүний хуудсуудыг шалгаж үзэв. ТХ-ны жирийн хэдэн ажилтны овог, заримынх нь утасны дугаар, заримынх нь хаяг байна, бусад нь танихгүй хүмүүс... Гэтэл хавтасны дотор тал баахан үрэгдсэн байхыг үзвэл харандаагаар ямар нэг юм тэмдэглээд, дараа нь өөр газар шилжүүлж бичсэнийхээ дараа хуучнаа ердийн балруураар арилгадаг бололтой. Хааш нь шилжүүлж бичив? Өдрийн тэмдэглэлд үү?

-Кунгуровыг нэн даруй баривчил, тэгээд өнөөдөрт багтаан байцаа гэж Сталин Паукерт тушаав. -ТХ-ны ажлын тухай, ТХ-ны ажилтнуудын тухай ямар тэмдэглэл хөтлөж байсныг нь байцаалтын явцад тогтоох хэрэгтэй. Бүх тэмдэглэлийг нь тэр даруй надад өгөөрэй. Албаных нь ширээг нэгж, орон байрыг нь нягтлан нэгж, түүний гараар бичигдсэн аливаа зүйл, түүнчлэн сэжигтэй гэхээр юу байна, бүгдийг нь надад өгөөрэй. Хэрвээ өөрөөс нь юу ч олдохгүй бол, Кунгуров хаана, хэнийд тэмдэглэлээ хадгалж болохыг тогтоож тэнд нь бас нэгжлэг хийх хэрэгтэй, холбоотой хүмүүсийг нь баривчлах хэрэгтэй. Тэр бол тагнуулч, ТХ-ны ажлын тухайн тагнуулын тэмдэглэл хөтлөж байсан байна.

Кремлийн өрөөний Кунгуровын ширээ, гэр орныг шалгасан боловч ямар ч бичиглэл,

тэмдэглэл олсонгүй. түүний болон авгайнх нь эцэг эхийн байрыг нэгжээд бас үр дүнд хүрсэнгүй.

Бүхий л аргыг хэрэглэж байцаасан боловч, Кунгуров өдрийн тэмдэглэл хөтлөж байсан гэдгийг ор тас үгүйсгэжээ.

Гэхдээ японы тагнуулын албатай хамтарч ажиллаж байсан, нөхөр Сталиныг алах гэж байсан гэдгээ хүлээжээ. түүнийг долоо хоногийн дараа буудан алжээ. Авгайд нь найман жилийн хорих ял оноож, хүүхдүүдийг нь асрамжийн газар явуулж, өөрийнх нь, бас авгайнх нь эцэг эхийг Москвагаас зайлуулсан ажээ.

Шпигельглас Шарокт, сургуульд үзсэн хэлний чинь суурь их тус болно хэмээсэн нь үнэн болж, хэлэндээ овоо зүгширч байв.

Ямар азаар юм, бүү мэд, аавынхаас нь франц хэлний сурах бичиг, хичээлийн хэдэн нимгэн дэвгэр энэ тэр нь олджээ. Энэ үнгэгдэж, шарласан ном дэвтрээс олон зүйлийг сэргээн санаж, арай ч адгийн гэхээргүй хүн шинэ багштайгаа золгожээ.

Өөрөөс нь арваад ах тэр багш албархаг, хөндий царайлаад, гол нь дуудлагаар их өөнтөглөж шахна. Шарокийн хувьд хамгийн хэцүү юм нь тэр. Ялангуяа “р” үсэг ердөө эвлэж өгдөггүй, чөтгөр авмар чинь!

-Зөөлөн, зөөлөн дууд, хөндий дуудна гэдэг чинь тультрана гэсэн үг биш, арай зөөлөн, намайг дагаад дуудаарай.

Шарок дагаад л давтана, гэвч олигтой болдоггүй.

-Та энэ авианд дасах ёстой, одоохондоо орос үгэн дээр дасгал хийж бай. Гэртээ, авгайтай ярьж байхдаа, “р” үсгийг миний хэлүүлэх гээд байгаа шиг дуудаж үзээд бай.

-Надад авгай байхгүй гээд Шарок инээмсэглэв.

Багш энэ мэдээллийг төдий л ойшоосонгүй.

-Тэгвэл сонин дуудаж уншиж болно, бас их ашигтай.

Шарокт авгай байхгүй. Каля гэж нэг хүүхэн бий. түүнтэй трамвайнд танилцжээ. Трамвай ирэхэд, Тэрээр нэг сайхан хүүхнийг гишгүүр дээр гарахад нь дэм болж, пиг дүүрэн вагон руу бэлхүүсдэн түлхэж оруулаад, гараа буцааж авахаа мартсан мэт шахцалдаан дунд тэр чигээрээ хэсэг явсан юм байж. Харангуутаа түүнд нүд нь унасандаа тэр.

Каля Грауерманы нэрэмжит төрөхөд эх баригчийн ажилтай. Тэрээр жижүүрээсээ буугаад, сард дөрөв, таван удаа Шарокийнд ирж, хаалганых нь хонхыг хоорондоо тохирсон ёсоор гурвантаа огцом дарж түүнийг сэрээхэд, цаадах нь шууд босгон дээр үнсэж үмхлэн, салж чадахаа болино. Шөнийн байцаалтаас нажидаа эдлэж, уурын мунхагаар өөрийгөө тарчлаасны дараа Каляг нэгэнтээ шүргэхүйд бие нь тавиран, сэтгэл тайвшрах бүлгээ.

-Аль вэ, пальтогоо хэмээгээд, түүнийг гарыг нь ч тавилгүй, өрөө рүүгээ авч орно.

Хүүхэн үдэш өөрөө хайрсан боорцог сэлтгэй бяцхан боодлоо ширээн дээр хаяж, хувцсаа тайлаад, дулаан хэвтэр рүү умбан орж явчихна. Дараа нь тэр хоёр нөгөө боорцогноос идэж, цай ууж байхдаа, том чийрэг гартай хөгжүүн хүүхнийг талимааран харж, Калерия гэдэг ер бусын нэр хаанаас олсныг шалгаана.

-Санваартан гаралтай юм уу, эсвэл худалдаачин удамтай юм уу?

-Үгүй шүү хэмээн цаадах нь инээд алдана. -Бид цэвэр пролетари гаралтай, ухаад ухаад өөр юм олохгүй.

Каля таарсан нь ёстой аз, яриад яахав. Одоо гадаад хэлтэст шилжсэн учраас шинэ хуваарь зохиох хэрэгтэй, тэр хоёр арай ойр ойрхон уулзах боломжтой ч байж магадгүй.

-Сонин дуудаж уншиж байна уу? гэж багш нь асууна.

-Уншиж байгаа, өдөр болгон.

-Сайн байна, цаашдаа ч уншаад байна шүү.

Юра хэлээ урамтай, дуртай, шимтэн үзэж байлаа. Гадаад хэлтэст өгсөн нь гадаад хэргийн ардын комиссариат руу шилжүүлэх нэг дамжлага ч юм бил үү, хэн мэдлээ? Тийм тохиолдол байсан юм чинь.

Харин гар бууны буудлага, хүйтэн зэвсэг, тэсрэх бодистой харьцах, радио холбоо барих, нууц түлхүүрт мэдээ нэвтрүүлэх мэтийн тусгай бэлтгэлийн хичээлдээ тэгтлээ шимтэхгүй. мань хүн энэ мэтээр яах вэ дээ? Өөрийг нь арай тагнуулч болгох гээгүй юм байгаа биз дээ, тэртэй тэргүй мань хүн буян амласан ч тийм зүгт зүглэхгүй. Гэтэл эдгээр хичээлийг тэдний хэлтсийн бүх хүн заавал үзэх ёстой юм байж. Шарок улайрсан ч юмгүй, гойдын амжилт олсон ч юмгүй, гэхдээ хичээл таслахгүй явна.

Цагаантан цагаачдын холбогдолтой, бас Оросын нэгдсэн цэргийн холбооны (ОНЦХ) түүх, түүний зохион байгуулалттай холбогдолтой материалыг идэвхийлэн судлаж, тагнуулчийн мэдээ сэлтийг уншиж танилцаж байв. Мэдээний эзэд нь дугаар буюу далд нэртэй, түүний цаана ямар хүн байгааг эс мэднэ. Асууж лавлах ч үгүй. Хэрэгтэй гэж үзвэл хэлж өгнө биз.

“Последние новости”, “Возрождение”, “Иллюстрированная Россия”, “Часовой”... гэхчилэнгийн цагаачдын сонин сэтгүүлийг уншихдаа хужирхай нь тэнийх шиг болно. Хэзээ ч ийм юм уншиж яваагүй болохоор нүгэлтэй шунаж уншина. Энэ муусайн сониноос ганцхан дугаар хадгалсан хүнд манайд наад зах нь арван жил өгөх ёстой, хэрвээ тэр сонины эзний холбоотнуудыг о л в о л, өөрөөр хэлбэл, өөрт нь хэн өгсөн, тэр нь хэнээс авсан, бас өөрөө хэнд үзүүлсэн, үзүүлэхэд хэн хэн байсан, тэд нар юу юу ярьсан гээд бүлэглэсэн хэрэг бүрдүүлэх юм бол, уг сониныг гартаа барьж үзсэн бүх хүнийг цаазаар авах нь гарцаагүй.

Зөвхөн гарчгийг нь л бод доо: “Зөвлөлүүдийн дарлал дор”, “Москвагийн хараа-тагнуулчид, өдөөгчид”, “Большевикууд юунаас айж байна вэ?”, “Большевик халдвар”. Эдгээр болон энэ мэтийн үгс эхлээд дургүй хүргэдэг байснаа сүүлдээ дэндүү нэг янз нь мэдэгдэж аяндаа дасч залхсан, уул нь “манай төрөлх улс орны” тухай зарим нэг сонин мэдээлэл байх нь байгаа.

Ийм уншлаганы давс хужир нь, жинхэнэ амт нь өөр юманд байгаа болой. Шарок хувьсгалын өмнөх Орос орны амьдрал байдал руу умбан орсон гэлтэй, тэр тухай өөрт нь хүүхэд ахуйн бүүр түүрхэн дурсамж бий, бас эцэг эхийнх нь хууч яриагаар дамжин толгойд нь хоногшсон зүйл бий. Элдэв цол хэргэм, овог нэр нүднийх нь урдуур жирэлзэнэ: ноён, тайж, гүн; Милюков, Волконский, Оболенский, Гучков, Рябушинский... Сүм хийдийн нэрс жирэлзэнэ:

Александр Невскийн гэгээн сүм, Эх дагинын мөргөлийн хийд, Бүгд Гэгээнтний дуган, Гэгээн Николайн хийд... Оршуулгын газар Сент-Женевьев де Буа, энэ оршуулгын газрын Галлиполийн хэсэг, Булонь-бианкур... “Бурхны тааллаар нас нөгчив...”, “Нас нөгчсөний дөчдэх хоног”, “Нас нөгчсөний нэг жилийн ойд...”. Казакуудын холбоо, Дон, Кубань, Терийн казак цэргийн баяр, генерал Корниловын Кубанийн аянд оролцогчид... Ресторанууд: “Мартьяныч”, “Корниловынд”, “Киев”...

Деникин Шопены танхимд лекц уншсан байна. Уран цэцэн үгээр булж, уриа лоозон хашгираа биз... Гэвч тэдний ярьж, бичиж байгаа юм Зөвлөлтийн хувьд ямар ч аюул занал байхгүй, цагаан гвардийнхны бүх байгууллагад манай тагнуул шургалаад, бүхэл бүтэн сүлжээ бүрэлдчихсэн байгаа. Тэр эрхэм дээдэс, эрхэмсэг ноёнтон гээд байгаа цол хэргэм сохор зоосны үнэ цэн байхгүй, таксины жолоон дээр сууж яваа ахмад бол ердөө л жолооч, Рено заводын дамжлага дээр байгаа хурандаа бол ердөө л жирийн ажилчин.

Тэглээ ч гэсэн, энэ бүхнийг эс харгалзан, жинхэнэ орос ёс уламжлал чухамхүү тэнд хадгалагдаж байгаа аж. Харийн газар шороон дээр сэтгэл зүрхээрээ өөрийнхөө Оросыг, зохиомол бяцхан ертөнцийг бүтээн босгоод түүнээсээ зуурцгааж байна. Хөөрхий-лөлтэй үзэгдэл, гэхдээ сайн ч, муу ч орос хүмүүс юм чинь, аль нэгэн зүйлээр сэтгэлийн чавхдас хөглөх бүлгээ.

Гэхдээ мөхөх тавилантай. Тэр Паристаа төрөл арилжицгаана, Сент-Женевьев де Буа-д тэднийг оршуулна, харин үр хүүхэд, ач зээ нар нь франц эсвэл герман, эсвэл серб болон өсч торницгооно. Тэр хөгшчүүл мөрөөрөө байж байгаад үеэ өнгөрөөмөөр, гэтэл үгүй шүү, эвлэрэхийг хүсэхгүй, тийчигнэцгээх юм. Жишээлбэл, өөрийнх нь эцэг эх хувьсгалаас болж хохирсон ч, хувь заяатайгаа эвлэрсэн шүү дээ. Бас мань Шарок ч захирагдсан. Энэ улсын бяр хүчийг хэн ч дааж тэсэхгүй. Тийм учраас бууж өгсөн хэнд ч болов ичих зовох юм үгүй. Доголонгийн газар доголон гэдэг. Гэтэл тэднийг тэр Парист албадан доголуулах гэсэн хэн ч байхгүй. Номхон, томоотой сууж байвал л болох нь тэр. Гэтэл үгүй шүү, улс төр рүү зүтгэлээд байх юм. Хориод онд цагаач цагаантнуудын дунд эрүүл чийрэг, залуухан офицерүүд бишгүй байсан, тэд нарыг тодорхой хүч байсан гэж болох. Гэтэл одоо... Хувьсгалаас хойш хорин жил өнгөрчихөөд байхад... ЗСБНХУ руу тагнуулч явуулж байна уу? мань хүн энд гурван жил ажиллах хугацаандаа нэг ч тагнуул үзээгүй. Ийм юм ярих нь инээдэмтэй хэрэг.

Шарок нэг багц сонин уншиж дуусаад, тоо ёсоор хүлээлгэн өгч, шинэ багцийг мөн тоолж хүлээж авна. Шпигельглас хэлтэс дээрээ тааралдахдаа, түүний юутай танилцаж амжсаныг лавлаад, цагаач цагаантнуудын тухай номнууд өгч,

-Гүйлгэж хараарай, сонин шүү гэнэ.

Тэгж байтал Шпигельглас үзэгдэхгүй долоо хонов. Хилийн чанадад явсныг Шарок ойлгожээ. Гэхдээ хаашаа явсныг хэн ч эс мэднэ, лав л Шарокт тэгж санагдана. Ер нь хүмүүс алга болчихдог, эргээд ирдэг, дахиад яваад өгдөг билээ. хүн болгон зөвхөн өөрт оногдсон үүргийн хүрээнд ажиллана, өөр юу ч сонирхохгүй. Асуулт тавих ёс байхгүй. Хэдийгээр Молчановын хэлтсийг улс төрийн нууц хэлтэс гэх боловч энд олон дахин давуу нууцлалтай. Тийм учраас Юра өөрснөө яриа үүсгэхийг нь хүлээн, элдэв асуулт хэнд ч эс тавина.

Сар орчмын дараа эхний яриа болов.

Шпигельглас өөр дээрээ дуудаж, хичээл сургуулийнх нь тухай лавлаж, ОНЦХ-той холбогдсон хэдэн асуулт тавьснаа,

-Танд хилийн чанадад танил бий юү? гэж асуув.

-Ямар утгаар?

-Шууд утгаар. Хилийн чанадад хамаатан садан, найз нөхөд, зүгээр танил хүмүүс, эсвэл таныг зүсээр чинь мэдэх гадаадын хүн бий юү?

-Бий.

-хэн, хаана?

-Парист Виктория Андреевна Марасевич гэгч нэг хүүхэн бий, нэрт профессор Марасевичийн охин. Би түүнтэй Кривоарбатскийн хөндлөн гудамны долдугаар сургуульд цуг сурч байсан юм. Тэр сургуулийн тухай би өнгөрсөн удаа танд ярьж байсан. Та мэддэг юм шиг байсан уу?..

Шпигельглас дуугарсангүй.

Шарок ийм асуулт тавьсан нь илэн далангүй ярилцаж, франц хэлний багш Ирина Юльевнаг хаанаас мэддэгийг нь тодруулах санаатай байж. Энэ бол түүний бүдүүлэг алдаа. Энд тийм саваагүй занг сайшаадаггүй, дарга чинь чиний мэдвэл зохих зүйлийн хүрээг өөрөө мэднэ, тийм учраас хэлсэн зүйлд нь сэтгэл ханаж байх ёстой.

Шпигельглас юу ч болоогүй мэт царайлж, дуугарахгүй байгаа нь зохисгүй асуулт тавьсныг өөрт нь үзүүлж байгаа хэрэг.

Шарок түүний дурамжхан буйг анзаараагүй дүр гарган, тайван үргэлжлүүлэв:

-Харин тэр Виктория Марасевичийн ах Вадим бид хоёр нэг ангийнх. Виктория Андреевна бидэнтэй гучин дөрөв, гучин таван онд хамтран ажиллаж байсан, гадаадынхантай орооцолдоно, дараа нь нэг нэртэй уран барилгачтай суугаад, хамтын ажиллагаанаасаа татгалзсан. түүний өгсөн ам өчиг хадгалаастай байгаа. Хожим тэр уран барилгачаасаа салж, сонинчин францтай суугаад, түүнийгээ дагаад Парис явчихсан юм.

Шпигельглас Шарокийг сонсох зуур дэвтэртээ тэмдэглэл хийж байв.

-түүнийг хэн хөтлөж байсан бэ?

-Би.

-Муудалцаж салсан уу?

-Тэгэлгүй яахав. Тэр хүүхэн нөхөртөө хэлнэ, нөхөр нь Сталинд орж хэлнэ гэж сүрдүүлэх

болсон юм. Гэхдээ тэр хүүхэн хүнтэй суугаад ресторанаа хэлхээ холбоог тасласан учраас бид түүнийг орхисон юм.

-Гадаадын хүнтэй суусан юм бол таслаагүй л юм байна даа гэж Шпигельглас өгүүлэв.

Гярхай чөтгөр! Шарок яаж жинхэнэ шалтгаанаа хэлэх вэ дээ? Вика тэр байранд Ленаг харчихаад, өөрийг нь илчлэнэ гэж зангах болсныг хэлж байлтай нь биш.

Тэрээр дал мөрөө хавчив.

-Тэгэхэд миний дарга байсан Дьяков түүнийг тавьж болно гэж шийдсэн юм.

За мэдэв үү! Шалгаж чадахгүй шүү дээ, эрхэм нөхөр Шпигельглас гуай. Одоо Дьяков хаа байгаа, бүү мэд.

-Тэр хүүхний ам өчгийг бид авна. Хүүхэн гадаадад амьдарч байгаа учраас ам өчиг нь манай хэлтэст байх ёстой. За, ийм байна! гээд Шпигельглас түүн рүү харахад, Шарок түүний харцнаас өөрт нь ёозгүй байгааг анх удаа олж үзэв. -Маргааш та зуслангийн байр руу шилжиж, тэнд нэг хэсэгтээ байх болно, цанаар гулгана, энд үзэж байсан хичээл сургуулиа хийнэ, сониноо уншина, ОНЦХ-ны материалаа судлана. Ганцхан хүсэлт бий: сахлаа битгий хусаарай.

Ойлгомжтой! Гадаад төрхийг нь өөрчлөх гэж байх нь. Тэгэхээр хилийн чанад гэсэн үг. мань хүнийг тийш нь цөлөх нь, тийм аргаар нэг мөсөн салах нь. Сумны бай, эсвэл шоронгийн тав болгох нь.

Шарок ам нээсэнгүй.

Шпигельглас түүн рүү асуусан харцаар харав.

-Ямар нэг юм таны сэтгэлд нийцэхгүй байна уу?

-Юу л даа, хэмээн Шарок үгээ цэнэсхийн эхлэв. -Николай Иванович...

мань хүн “Ежов”, “нөхөр ардын комиссар” гэж хэлсэнгүй, өөрт нь түүний талтай гэдгийг цохож, зориудаар “Николай Иванович” гэж хэлжээ.

-Николай Иванович надад хэлэхдээ намайг гадаад хэлтэст шилжинэ, миний цаашдын ажил үүргийг нөхөр Шпигельглас хэлж өгнө гэсэн юм. Би энд ирээд сар боллоо, одоо хэр өөрийнхөө ажил үүргийг мэдэхгүй явна. Та намайг нэг ажилд бэлтгэж байна, чухам ямар ажилд гэдгийг би мэдмээр байна.

Ийнхүү шууд ярих нь аз үзэхтэй адил гэдгийг Шарок ойлгож байв. Гэвч өөр арга алга. Эд нар өөрийг нь хорлон сүйтгэх ажлын хэсэгт оруулахаар бэлтгэж байна, энэ бол гарцаагүй үхлийн зам. Тэрээр аль ч талаас нь бодсон тийм ажилд бэлтгэгдээгүй. Хэл мэдэхгүй, маруухан буудна, үе мөчний архаг хууч нь яг эгзэгтэй мөчид хэвтэрт оруулж мэднэ. Ердөө мэргэжлийн хуульч хүн. Хуульч гэдгээр түүнийг ДЯАК-д мөрдөн байцаагчаар авсан. Өөр ямар ч ажил

хүсэхгүй байна. Ингэх гэж Ежов түүнийг гадаад хэлтэст шилжүүлээгүй, үүнд өөрөө итгэлтэй байна. Тэгвэл яах гэж шилжүүлэв? Ийм асуулт Слуцкий, Шпигельглас хоёрыг ч зовоож байгаа бололтой, Шарок тэдэнд хэрэггүй, тэгээд салахын мөн болж байна. Тэр бүтэхгүй шүү.

Ингэж бодоод,

-Хэлтэст ямар үүрэгтэй байх талаар би Николай Ивановичоос асуух нь эвгүй гэж бодсон юм. Яах нь мэдэгдэхгүй ингэж удахыг мэдсэн сэн бол би, мэдээж, түүнээс асуулгүй яахав гэж нэмж хэлэв.

Ежов дээр орно, тэндээс дэм авна гэж ойлгуулж байгаа нь тэр.

-Таны ажлын тухай би бүр эхнээсээ танд хэлсэн шүү дээ хэмээн Шпигельглас тогтуухан хэлэв. -Та ц а г а а н т н а а р ажиллана, ОНЦХ-г хариуцдаг хэсэгт орно гэж хэлээ биз дээ. Тийм учраас би таныг түүний үйл ажиллагаатай танилц, ер нь цагаач цагаантны тухай мэдэж ав гэж хэлсэн юм. Таныг хилийн чанад дах тагнуулын ажилд бэлтгээгүй, та бол Өрнөдийн амьдрал байдлыг мэдэхгүй, олон хэл мэдэхгүй, та бол тэнд балрана. Таны ажлын байр энд байх болно. Гэхдээ энэ бол Өрнөд рүү явах, газар дээр нь аман мэдээлэл авахаар манай ажилтнуудтай уулзах энэ тэрийг үгүйсгэхгүй. Удахгүй та тийм ажлаар явах болно. Ингэхэд...

Тэрээр түр азнаснаа нөгөө нэгэн хэмийн тогтуун дуугаараа үргэлжлүүлэв.

-Ингэхэд, Николай Ивановичийн заалтын дагуу та надтай Парис явна. Тийм учраас би таныг кафе, ресторан, зочид буудал, метро энэ тэрд амиа тээх хэдэн франц үгтэй болог гэж бодсон юм. Арай төвөгтэй байдал бол би л ярина. Гэхдээ а ж и л т ө р л и й н талаар бол зөвхөн оросоор ярина. Таныг аюулаас хамгаалахын ажилтан гэж сайн мэддэг Виктория Андреевна Марасевич Парист аж төрж байгаа. Тааралдах магадлал бага, гэхдээ болгоомж илүүдэхгүй, тийм учраас би таныг сахал, хуузаа ургуулаарай гэсэн юм, дээр нь нэмж шил зүүх хэрэгтэй болно. Тусгай бэлтгэлийн тухайд гэвэл, ажил, зиндаа харгалзахгүй манай хэлтсийн бүх ажилтан хичээллэх албатай. Та энэ тухай мэднэ. Хийсэн сургууль чинь танд хэзээ ч хэрэг болохгүй байх гэж найдаж байна. Гэхдээ эзэмшсэн байх зайлшгүй шаардлагатай. Миний ярьсан зүйлд сэтгэл ханав уу? А-аа, бас нэг зүйл... Москвад төрөл садан, танил талын хэн боловч таныг явахаас өмнө харах ёсгүй. Бүх юм тодорхой юу?

-За, бүх юм тодорхой гэж Шарок хариулав.

Люда өглөөний ундан дээр бараг юу ч идэлгүй, дарсан өргөст хэмхний шүүснээс хомхой гэгч нь хэд залгилаад, пальтогоо өмсөж, Сашад бэлэн байхыг анхааруулаад хонгил руу сэмхэн шагайснаа, түүнийг хуруугаараа дуудан, Даша эмгэний өрөө рүү дагуулж оров.

-Хоёр минут хэртэй болоод та хоёр цуг гараарай, би булангийн цаана хүлээж байя.

Болгоомжилсон нь зөв болж. Хонгилд нэг эрэгтэй хүн хэдийн гарч ирээд, түмпэн дээр тонгойчихсон нүүр гараа угааж байна, өөр нэг өрөөний үүд онгорхой, нэг хүүхэн шалаа шүүрдэж байна.

Нүүр гараа угааж байсан хүн ер тоосонгүй, харин нөгөө хүүхэн Саша руу ихэд шимтэн харлаа.

Люда булангийн цаана хүлээж байв. Тэр хоёр хөндлөн гудам уруудан, дараачийн гудамж руу ирлээ. Людагийн бүрзэн андаш алга, доод хоёр зовхи нь хөвхөртөөд шалхайчихаж. Сашатай хараа мөргөлдмөгц,

-Өчигдрийн юмнаас толгой өвдөж байна, чинийх ямар байна? гэж асуув.

-Зүгээр.

-Елизавета энд суудаг юм, аль вэ, паспортоо өгөөтөх! хэмээн Люда шинэхэн таван давхар байшин руу заав.

Саша дотроо тээнэгэлзэж байвч паспортоо өглөө.

-Чи өөрөө зайдуухан шиг хүлээж бай.

Тэрээр орц руу орж алга болов. Саша гудамжны нөгөө талд гарч, саяны орцыг харуулдах зуур хойш урагш холхиж эхлэв.

Саша Людагийн өчигдрийн ярьсан юманд тэгтлээ гайхшраагүй, тийм явдал газар сайгүй болж байгаа юм чинь. Харин хамаг юмаа уудлан ярьсанд гайхсан, одоо цагт хэн тэгдэг билээ дээ. мань хүн өөрийнхөө тухай түүнд бас ярьсан, нэгэнтээ т и й м паспорттой юм чинь нуухын арга байхгүй, аз туршаад байх ч юм үгүй. Харин Людагийн тухай, эцгийнх нь тухай, ахынх нь тухай хүн мэдэхгүй, өөрөө л чимээгүй байх юм бол хэзээ ч олж мэдэхгүй өнгөрнө. Согтуудаа ам алдчихав уу? Ёсонд хазгай. Согтуу ч гэсэн амаа татахаа мэдэж байна лээ.

Люда гараад ирлээ.

-Өнөөдөрт нь багтаагаад ёсоор болгоно, харин дэглэмийн ту-хайд бол, яг “дэглэмийн тухай” гэж хэлж байна лээ шүү, бүтэхгүй гэнэ. Өөрөө ч тийм юм хийхгүй, дарга нь ч хийхгүй гэнэ, таван жилийн хугацаатай, гэхдээ тэмдэглэл хийсэн паспорт авах нь байна. Яахаа шийд.

Саша бодлоо. Дахиад хэдэн сарын зай байна, тэр хооронд өөр арга зам олдож магадгүй,

харин олдхоггүй бол яах вэ? Людатай харилцаа хэвээр байх уу? Елизавета паспортын хэлтэст тэр чигээрээ байх уу? Гэтэл эндээс гэнэтхэн эрт явах болчихвол, хүн амьтан танихгүй шинэ газар паспортоо солиулах хэрэг гарна, тэгвэл сэргийлэхийн хонгилд өөрөө оочерлож, даргатай нь өөрөө биечлэн ярих хэрэг гарна.

-Яагаад дүлэгнээд байна, шийдээч. Шийдэж байгаа бол зургаа өгөөтөх, би аваачаад өгчихье, орой паспорт чинь бэлэн болно гэж Люда шавдуулав. -Бушуухан шийд, тэгэхгүй бол цаадах чинь ажил руугаа явчихна.

-Надад зураг байхгүй гэж Саша өгүүлэв.

-Би яг тэгж бодсон юм. Бүр “маргааш л авчирч өгөх байх” гэж тэр хүүхэнд хэлснийг яахав. Одоо зурагчинд оч, энд ойрхон байгаа, би заагаад өгье, паспортын зургийг түргэн гаргадаг юм, чи бас гуй, орой гэхэд гаргаад өгч мэднэ. Тэгээд автобааз руу оч, Леонидтэй уулзаж юу, яахыг мэдэж ав. За баяртай.

Тэгээд хэсэг азнаснаа,

-Хэрвээ өнөөдөр дотуур байранд оруулахгүй бол кафе руу очоорой, би өнөөдөр ес хүртэл ажиллана гэв.

Зураг маргааш нь бэлэн болов. Саша тэр даруй сэргийлэх рүү очиж, зураг, түр паспортоо тушаав. Елизавета паспортыг нь үзэж, зургийг нь зэрвэсхэн харснаа, албаны байдлаар,

-Маргааш арваас арван хоёрын хооронд ирж болно гэж хэлэв.

хүнээр хэлүүлсэн шинж алга, маргааш нь Сашаг ирэхэд байнгынх нь паспортыг олон таван үггүй гардуулав. Энэ ажил зуун рублийн өртгөөр бүтлээ. Энэ тоог Люда хэлсэн, мань хүн ч тэр дор нь мөнгөө түүнд өгсөн билээ. Гэхдээ паспортын “олгосон үндэслэл” гэдэг хүснэгтэд “ЗСБНХУ-ын ТГХ, АКЗ-ийн 1932.ХИ.27-ны тогт.” гэж шигүү бичсэн байв. Энэ бол “дэглэмтэй” хотуудад суухыг хориглосон тэмдэглэл буюу нөгөө “хар данс” гэгч нь.

Саша энэ хоёр шөнийг Людагийн хонув. Даша эмгэнтэй цуг гарч, хөршүүдэд нь харагдахгүй гэж үдэш орой болсон хойно Людатай хамт буцаж ирнэ. Өдөр нь хотоор сэлгүүцэн, аль нэг ажилчны гуанзанд хооллон, уншлагын танхимаар орж сонин эргүүлж явав. Бичиг баримтгүй учраас ном, сэтгүүл авч үзэх боломжгүй, харин хоёрдугаар сарын сонин ширээн дээр хэвтэж байна, ханатлаа уншихад саад болох юм алга. Саша тэсэлгүй нэгдүгээр сарын “Правда”-г гуйсанд номын сангийн ялдамхан хижээл авгай үдээтэй сонин авчирч өгөв.

Яг л нөгөө юм хэвээрээ... “Троцкист-зиновьевч сүргийн Киев дэх хуйхлагдсан хоёр нүүртнүүд”... “Киргизийн троцкист шаар”... Тэр ч байтугай ингэсэн байна: “Троцкийн хүү Сергей Седов гэж эцгийгээ дуурайсан зулбасага цахилгаан хөдөлгүүрийн хийгээр хэсэг ажилчдыг хордуулахыг оролджээ... Энэ фашист тийрэнгээс үйлдвэрийг чөлөөлж өгөхийг ажилчдын цуглаанаас аюулаас хамгаалах байгууллагад шаардсан байна...”

Хорин есөн онд Москвад яригдаж байсан нэг зүйлийг Саша санаж байна: Троцкийг

Зөвлөлтөөс хөөж гаргахад отгон хүү Сергей нь эцэгтэйгээ цуг явахаас татгалзаж, түүнтэй үзэл бодол нийлэхгүй байсан учраас ЗХУ-д үлдсэн юм. түүнийг ээжийнхээ талаас бол туйлын алдарт шинжлэгч Седовын зээ хүү юм шиг, бас түүнийг намд элсэхэд Сталин, Оржоникизе, Бухарин гурав батлан даасан юм шиг ярьцгаадаг байсан. Тэгсэн чинь одоо ажилчдыг хордуулж бхйдаг байх нь.

Ажилчдаас Ежовт ирүүлсэн мэндчилгээ, Ежовын өөрийнх нь том хөрөг, Ежовт Улсын аюулгүй байдлын Ерөнхий Комиссарын цол олгох тухай ЗСБНХУ-ын ТГХ-ны тогтоол, аюулаас хамгаалах байгууллагын ажилтнуудыг шагнах тухай... Шүүн таслах ажиллагаануудыг чадварлаг хэрэгжүүлсний төлөө ингэж байгаа юм байж. Пятаков-Радекийг шүүсэн тухай “Правда” сонины тэргүүн өгүүлэл: “Шаарны шаар”, мөн хорин хэмийн хүйтэнд Улаан талбай дээр цуг-лаан хийж, түүн дээр Хрущев, Шверник, ШУА-ийн ерөнхийлөгч Комаров нар шүүх хурлыг сайшааж, хилэнт үгээ хэлсэн тухай материал...

Тэр цуглаан дээр байсан хүмүүс юу бодож байсан бол? Итгэж байсан болов уу?

Шүүн таслах ажиллагааны тухай бүрэн материалыг уншаад, Саша тэдгээр яллуулагчдыг жигшин зэвүүцмээр болов. Гэтэл, нөгөө талаас, тэдний өөрсдийн нь мэдүүлгээс өөр баталгаа, нотолгоо хаана байна? гэж бодогдоно. Бүх улс орон даяар өргөн цартай дайсагнасан үйл ажиллагаа явуулж, хилийн чанадаас заавар, чиглэл авч байсан гэх атал ганц ч баримт, ганц ч захидал хүний урманд байхгүй; баахан алан хядах ажиллагаа бэлтгэсэн гэх, гэтэл нэг ч гар буу, нэг ч сум алга.

“Жүжиг” гэдэг үгийг Лидия Григорьевна Звягуро ахин дахин хэлэх дуртайсан, цэлмэг ухаантай авгай бүгдийг ойлгож байж дээ. Сталин эрүүгийн хэрэгтнээс дор, хэрэгтэй бол хэнийг ч ална гэж хэлэхээр нь мань хүн түүнтэй маргадагсан. түүний хэлж байснаар л болох царайтай.

Саша нөгөө ялдам авгайд “Правда”-г буцааж өгөөд, нэг, хоёрдугаар сарын “Литературная газета” өгөхийг хүсэв.

Тэнд ч бас ялгаа алга: буудан ал, устга... Бабель: “Хууралт, урвалт”, Ю.Тынжянов: “Шүүхийн ял-ард түмний ял”, ардын ерөөлч Жамбул: “Ардын комиссар Ежовын тухай найраглал”, В.Луговской: “Өнгөрсний цуст ноход”, Николай Тихонов, М.Ильин, С.Маршак: “Гестапо орох зам”, Андрей Платонов: “Хорт үйлийг гэтлэхүй”.

Туж алдар цуутны нэрс. хэн нь түргэн, хэн нь хурц хэлэх вэ гэж уралдах мэт. мань хүн, мэдээж, энэ бүхнийг шүүгч биш. Гэхдээ л ийм өгүүллүүд бичсэнийхээ дараа, яаж нүүр нүүрээ харцгаадаг юм бол? Тэр л сонин байна. Ард түмэнд ямар үлгэр үзүүлж буйгаа боддог болов уу?

За яахав, цааш нь уншъя.

Константин Федин: “Олон улсын хувьсгалын эсэргүү нарын төлөөлөгчид”, Новиков-Прибой: “Фашизмын хөлсний этгээдүүдийг жигшье”, Ю.Алеша: “Фашистууд ард түмний шүүхийн өмнө”, Леонид Леонов: “Хоёр нутагтны оромж”, Сергеев-Ценский: “Эд нар амьдрах эрх

байхгүй”, Р.Фраерман: “Бид тэднийг агуйнаас гэрэлд гаргана”...

мань Сашаг бол “агуйнаас гэрэлд гаргах” шиг амархан юм алга, өөрөө т э д н и й гарт очиж байна. Дайсныг ажилд авдаг дарга нарыг толгой түрийгүй шүүмжилсэн материал сониноор нэг байна: “Амурын төмөр замд Б. гэгчийг ажилд авсан, өөр нэг газар М. гэгчийг, гуравдахид нь П. гэгчийг авсан гэх. “Үүнтэй холбогдуулан, ажилтанг ажилд авдаг ялт тогтолцоо байгааг тэмдэглэх хэрэгтэй. Намтрыг нь нарийн нягталж судлахгүй, шилж сонгохгүй шууд авч байна” хэмээн сонин бичиж байна. Энэ бол шууд өөрийг нь хэлсэн үг, түүн шиг хүнийг ажилд авч болохгүй гэсэн шууд удирдамж. Муу шүү. Цаашаа ажил, амьдрал яахыг бүү мэд.

Орох хаалган дээр манаач сандлаасаа босч, хэнтэй уулзах гэж явааг нь Сашагаас асуув.

-Инженертэй.

-Засварын газар очиж хар, гараашаар дамжаад тийшээ очно шүү.

Хашаан дотор, хоёр урт саравчин дор баахан дугуйгүй машин зогсож байна, дугуй хүрэлцдэггүй хэрэг байх. Яг тэнд нь машины угаагуур байна. Модон гүүр, доор нь ус урсгах суваг.

Машинд зориулсан өргөн хаалгаар Саша бензин, ацетилин, хиншүү ханхалсан хоосон гарааш руу оров. Хэдэн слесарьч хоёр машинтай ноцолдож байна, бусад нь шугамандаа гарсан бололтой. Машины энэ үнэрийг авч, тос тортог болсон хөвөнтэй цамцтай слесарьчдыг хараад, Дорогомиловын химийн заводад жолооч хийж байснаа шууд санах. Багш нь Илюшка гэж сайхан сэтгэлтэй алт шиг залуу байж билээ.

Өглөөгүүр, бараг үүрээр, тэр хоёр заводоосоо гараад, Москва голын эргийн эзгүй засмалаар хурдалж өгнө.

-Хийгээ хас, хийгээ хас! Жолооноос буулгана шүү, сайхан мэдээрэй! гэж Илюшка хашгична.

Сашаг хурдаа саангуут Илюшка тайвширч, сэтгэлтэй бүсгүйнхээ тухай ярьж алдана. Бүсгүй нь нэг удаа түүнээс Горькийн паркт бүжигт дагуулж очихыг шаардаж. Илюшка насныхаа талыг хөдөө өнгөрөөсөн, элдэв үнэгэн шогшоо энэ тэр гэж ёстой дуулаагүй, нийтийн бүжиг мэдэхгүй хэрнээ ичээд хэлж ч чадсангүй.

-Өө, тэр яахав, би зааж сургана гэж Саша амлажээ.

Тэр хоёр гараашдаа буцаж ирвэл тэнд хоёрхон машин байж: захирлын “роллс-ройс”, тэдний ачааны машин, тэгэнгүүт түүнийг засах гэж байгаа улс болж хаалгаа дотроос нь түгжчихээд, Саша бүжиг зааж гарчээ. Илюшка ганц хүний бүжигт гарамгай, босч суухаас авахуулаад арван зургаат товшилж энэ тэр элдэвлэж байвч үнэгэн шогшооны наад захын гишгэдлийн эвийг олдоггүй.

Хоюулаа гар гараасаа барилцаж байгаад Саша командлана:

-Алхам зүүн тийш... Алхам баруун тийш... За-аа, нэг! За-аа, хоёр!

Илюшка хөлөө харан будилна.

-Толгойгоо дээш нь, над руу хар! хэмээн Саша шаардана. -За-аа, нэг! За-аа, хоёр!

Зай багатай учир Саша Илюшкаг хананы ёроолоор баруун, зүүн тийш нь холхиулна: “За-аа, нэг! За-аа, хоёр!”

Хоёр хоногийн дараа тэд нар Нинагийнхаар орж, Саша Варягийн ганц пянзтай эгшигт хайрцгийг түр барихаар түүнээс авав. Пянзны нэг тал дээр үнэгэн шогшоо, нөгөө тал дээр нь танго байгаа. Тэгээд жижигхэн гараашаа дахин түгжиж, эгшигт хайрцаг тавьж байгаад Саша хөгжмийн аяар “За-аа, нэг! За-аа, хоёр!” гээд л командлаж гарч дээ.

Илюшка хожим ажил дээрээ бөөн баяр болсон амьтан ирсэн: Бүсгүйтэй соёл, амралтын паркт очиж, үнэгэн шогшоо битгий хэл, танго, румба хүртэл бүжиглэсэн гэнэ. Бүсгүй эхлээд түүнийг магтаж байснаа, сүүлдээ “хэн зааж өгсөн?” хэмээн бараг хардах юм болж. Тэгэхээр нь мань хүн, “Манай завод дээр заадаг юм, Панкратов гэж зориудын сургагч бий” гэж хэлж. Нөгөө бүсгүй нь сайн сургагчтай юм байна гэж Сашаг магтсан гэх. түүнээс хойш Илюшка түүнийг жигтэйхэн хүндлэх болж, замд явахдаа өөчлөхөө больсон төдийгүй шалгалтанд бэлтгэхэд нь туслах болжээ.

Сайн хүмүүстэй цуг ажилласан сайхан цаг байж дээ, тэдний тухай санахаар дотор бүлээсэх шиг болох юм.

Саша Леонидыг тэвшний цехээс олов. Леонид шон түшчихээд, бөөн будаг болсон хувцастай, багс бариад тэвшин дээр зогсож байгаа Глебтэй ярилцаж байв. Сашаг хоюулаа тэр даруй танилаа. Глеб цагаан шүдээ яралзуулан мэндлэв. Леонид толгой дохиж,

-За орохоор болов уу? гэв.

-Тэглээ.

-Өргөдлөө авчирав уу?

-Авчирсан.

-Аль вэ, өгөөдөх, бас үнэмлэхээ.

Леонид үнэмлэхийг түрүүн үзсэн болохоор өргөдлийг нь уншиж үзэв. Тэгээд,

-Эндээ хүлээж бай гэчихээд яваад өгөв.

Глеб тэвшин дээрээс харайж буугаад, Сашагийн хажууд сууж, “Беломор”-оо гаргав.

-Тамхи тат, ялдам минь, энд хориотой ч гэсэн яахав.

Тамхиа асаацгаалаа.

-Сүүлчийнхээ тэвшийг будаж байна, лайтай ажил, гэвч “зоос хэрэгтэй” болохоор яая гэхэв, чамд “зоос хэрэгтэй” юү?

-Мэдээж.

-Бүх хүнд хэрэгтэй гэж Глеб айлдав. -Энэ муу зоосноос болж, суут хүмүүс хүртэл хамгийн хар бор ажлыг хийж байсан юм. Ренуар гэдэг нэрийг мэдэх үү?

-Мэднэ гээд Саша инээмсэглэв.

-Ренуар сав суулга хээлдэг, Крамской гэрэл зургийн газар пленкон дээр засал хийдэг байсан юм, бас Поленов, тийм хүнийг мэдэх үү?

-Поленовыг бас мэднэ.

-Поленов юу гэж хэлсэн гээч: хаяг зурахад ер муу юм байхгүй гэж айлдсан. Тэр хаяг хийж байж, би тэвш будаж байна. Өөр эрин юм чинь.

Леонид эргэж ирж, Сашад жолоочийн үнэмлэх, өргөдөл хоёрыг нь өгөв. Өргөдөл дээр баазын дарга “Хоёрдугаар цуваанд жолоочоор авах” гэж цохжээ.

-Хоёрдугаар цуваа гэдэг нь гурван тоннын ЗИС-5. Хоёрдугаар зэргийн жолоочийн шалгалт өгчихвөл автобус руу шилжүүлнэ. Одоо конторт оч, нарийн бичгийн даргатай уулз, тэр хүүхэн бичиг цаасыг чинь ёсоор болгож өгнө гэж Леонид тайлбарлав.

Нарийн бичгийн дарга захирлын үүдний өрөөнд суудаг аж. Бичгийн машин дээр юм цохиж байна. Захирлын хаалган дээр Прошкин Н.П. гэсэн жижигхэн хаяг хаджээ.

Саша өргөдлөө ширээн дээр нь тавив. Хүүхэн машинаасаа гараа салгалгүй түүн рүү хялайсхийн харлаа:

-Мэдлээ. Сүүлчийнхээ ажлын газрын тодорхойлолтыг үлдээчих.

-Би хаячихсан, надад байхгүй.

Хүүхэн өлийж харав.

-Би бүх бичиг баримтаа хаячихсан гэж Саша нэмж хэлснээ, -Үгүй ээ, хаях юу байхав, хулгайд алдчихсан юм гэв.

“Хулгайд алдчихсан” гэхийг сонсоод өрөөнд байсан бусад гурван хүн цааснаасаа толгой салгаж, түүн рүү харцгаав. Хуузтай хоёр өвгөн, нэхмэл цамцтай нэг охин.

-Паспортыг чинь бас уу?

-Бас паспортыг. Оронд нь надад шинийг өгсөн гээд Саша паспортоо гаргаж үзүүлэн, -Дөнгөж өчигдөр авсан, сар өдөр нь энэ байна гэв.

Хүүхэн бодлогошрон хөмсөг зангидсанаа, Сашагийн өргөдөл, паспорт хоёрыг аваад дарга руугаа оров.

Энэ Прошкин Н.П. гэгч юу гэж шийдэх бол хэмээн Саша түгшүүрлэн бодов. Ямар “үндэслэлээр” паспорт олгосныг шууд анзаарна. Тэгээд гарцаагүй татгалзана. Сэжигтэй хүнийг яах гэж хүзүүн дээрээ тавих билээ? Дараа нь “сонор сэрэмж алдсан” хэргээр яллуулна.

Саша нэг сул сандал дээр суув. түүнийг анзаарч байгаа хүн алга. Охин сампингийнхаа эрхийг тачигнуулж, нэг өвгөн тооны машинаа хурр, хурр эргүүлэн, нөгөө нь дансаа шагайгаад суучихаж.

Тэгж тэгж нарийн бичгийн дарга гарч ирээд Сашад паспортыг нь өгөв:

-Дарга сул машин байхгүй гэж байна.

Саша яахаа бодон, гарахаа яарсангүй. Захирал дээр орж учраа олох уу? Жолооч хэрэгтэй гэж Леонид тодорхой хэлсэн шүү дээ. Бас л нэг доромжлуулахаас өөр ашиггүй биз.

Саша гарч яваад хонгилд Леонидтэй халз тулгарав.

-Болчихов уу?

-Үгүй ээ, захирал татгалзлаа.

-Юу? Нааш ир, юу болсноо ярь!

Тэр хоёр Леонидын жижигхэн өрөөнд оров. Онгорхой босоо шүүгээнд машины баахан эд анги байна. Ширээн дээр нь үнсний савны оронд тамхины иш дүүрсэн бортого байна.

-Тэр чамд юу гэж байна?

-Би түүнтэй уулзаагүй. Үүдний хүүхэн түүн рүү орж ирээд, жолооч шаардлагагүй гэж мэдэгдлээ.

-Шаардлагагүй гэж юу гэж байгаа юм бэ?! гээд Леонид Саша руу муухай харав. -Надад зургаан машин жолоочгүй байна, бас зургаан машин ганц ээлжтэй!

Саша жуумалзав:

-Надад тэр чинь ямар хамаа байна? Би ажлаас татгалзаагүй, намайг авахаас татгалзлаа шүү дээ.

-Өргөдөл чинь хаана байна?

-Дарга дээр чинь үлдсэн.

Леонид хараал тавиад, өрөөнөөс гарав.

Саша ганцаараа үлдэв. Цонхоор гараашийн хашаа, машиныхаа дэргэд байгаа жолооч нар энэ тэр харагдана. Леонид юу ч бүтээхгүй дээ, илүү ажил.

Леонид баргар царайлан буцаж ирж, чимээгүй жаахан сууснаа,

-Чи яасан гэж ял эдлэсэн юм бэ? гэж асуув.

-Яагаа ч үгүй. Сургууль дээр нэг тэнэг явдал болсон юм, манай ханын сонин сэтгэлд нь таараагүй юм.

-Ээ, бас гэж Леонид халаглав. -Гэхдээ захиралд ч бас үндэслэл байна.

-түүнд чинь ямар ч үндэслэл байхгүй. Үндсэн хуулиар би хөдөлмөрлөх эрхтэй юу, үгүй юү?

-Чи байна шүү, мужийн авто тээврийн газарт өргөдөл биччих гэж Леонид санал хэлэв. -Овог нь Табунщиков. Ийм асуудлыг шийдэж чадна.

Саша түүн рүү бодлогошрон харав. Нэг бодол зурсхийж... Азаа үзэх үү, яахав?

-Чи надад цаас өгөхгүй юү? гээд Саша үзэг авч, бэхийг ойртуу-лан бичиж эхлэв. Леонид орж гарсан хүнтэй ярилцаж, заримдаа өөрөө орж гарч байвч саад болох юм алга. Саша зөндөөн удаан бичсэний эцэст, бичсэн юмаа нэг уншиж үзээд бослоо.

-Юу биччихэв, үзүүл дээ.

-Дараа үзүүлнэ ээ, одоо яарахгүй бол болохгүй. Чамд баярлалаа, байх тий.

Саша трамвайны зогсоол дээр дөрөв нугалсан өргөдлөө дэлгэж дахин нэг уншиж үзэв:

“БХК(б)Н-ын мужийн хорооны дарга

н.Михайловт

А.П.Панкратовоос.

хүндэт нөхөр Михайлов. Би 26 настай. Би бүх насаараа Москвад, Арбатын 51 дүгээр байшинд амьдарсан. 1934 оны нэгдүгээр сард намайг баривчилж, 58-ийн 10-аар гурван жил Сибирыг цөлөх ял оноосон юм. Хугацаа дуусч, намайг том хотуудад суух эрхгүйгээр чөлөөлсөн болно. Би Калининд ирж, хотын автобаазад ачааны машины жолоочоор орох гэсэн боловч баазын дарга Прошкин Н.П. надад татгалзсан хариу өглөө. Уул нь жолоочгүйн улмаас нэлээд машин зогсож байна. Үндсэн хуулиар би хөдөлмөрлөх эрхтэй, гэтэл эрхээ практик дээр хэрэгжүүлэх боломжгүй байна. Одоо би яах вэ? хүндэтгэн ёсолсон

Панкратов”.

Нэг өгүүлбэрийг өөрчилвөл зохилтой сон. Хэрвээ Михайлов түүнийг хүлээж авбал, “Та яагаад заавал Калининд ирсэн юм бэ?” гэж асууж мэднэ. Тэгэх үед хаяагаа манасан үг байсан бол яг болохгүй юү, жишээлбэл, “М и н и й х а м а а т а н б а й д а г Калининд ирж...” гэж бичдэг байж. Гэвч одоо нэмж бичих арга байхгүй, нэгэнт оройтож. Энэ чигээрээ байж байг, юу л болвол болог.

Энэ бол цөхөрсөн, магадгүй, ямар ч горьдлогогүй алхам. Гэвч өөр арга алга. Эндээс яваад шинэ газар очлоо гэхэд дахиад энэ лай эхлэнэ. Харин энд бол өчүүхэн ч гэсэн горьдлого байна, Михайлов гэнэт түүнийг санаж мэднэ.

Доод давхрын пропускийн товчооноос Саша Михайловын өрөө рүү утасдав. Туслах нь утсаа авлаа. Саша нөхөр Михайловтой уулзах хүсэлтэйгээ хэлэв.

-Ямар асуудлаар?

-Хувийн асуудлаар.

-Хүлээн авах дээр нэрээ бичүүлчих.

-Би маргааш явах юм.

-Ирэхээрээ бичүүлэхгүй юү.

-Тэгвэл түүнд захиа дамжуулахыг зөвшөөрнө үү.

-Бичиг хэрэгт өгчих.

-Танд энэ захидлыг биечлэн өгье, энэ чухал асуудал байгаа юм, би танаас гуйя.

-Овог, нэр.

-Панкратов Александр Павлович.

-Намын батлах чинь байгаа юу?

-Би нам бус.

-Паспорт?

-Байна.

Михайловын туслах махлагдуу намхан залуу аж. Босоогоороо Сашагийн өргөдлийг гүйлгэж хараад, түүн рүү хараа шилжүүлэхэд, түүнийг хаа нэгэн газар үзсэн мэт гэнэт санагдав. түүний царайг ажвал бас л яг тэгж бодож байх шиг. Хаа харснаа санаж ядан байна.

-Та паспортоо өг дөө.

Саша паспортоо өгөв.

-Та суузтаж бай хэмээн булангийн сандал руу заагаад, даргынхаа өрөө рүү орохдоо хиймэл сарьсаар бүрсэн хаалгыг сайн татаж хаав.

Мужийн намын хорооны даргын үүдний өрөө даруухан тоногтой аж. Албаны тавилга, албаны туузан дэвсгэр. Баруун гар талын хоёр цонхны хооронд Лениний “Правда” ушниж буй томруулсан гэрэл зургийг өлгөж, эсрэг талын хананд Сталины ганс зуусан гэрэл зургийг хаджээ.

Ингэхэд, энэ туслахыг хаана харсан байж болох вэ? Эсвэл ерөөсөө үзээгүй, зүгээр л хүн андуурч байгаа юм болов уу? Тийм ч бай, үгүй ч бай, ямар ч атугай, уриалгахан зан гаргаж, хүсэлтийг нь сонсон хүлээн авч, өргөдлийг нь Михайлов руу аваад орлоо. Тэглээ ч гэсэн хэрэг бүтнэ гэх горьдлого тун өчүүхэн байна.

Тэгсхийгээд туслах гарч ирж, дахиад хаалгаа сайн хаалаа. Тэр хаалганы цаана давхар хаалга байгааг Саша анзаарав.

Саша түүнийг тосон босов.

Туслах түүнд паспортыг нь буцааж өгөхдөө,

-Маргааш автобаазын дарга дээр очоорой, таныг ажилд авна гэж хэлэв.

Тэгэхээр Михайлов түүнийг эргэж санасан байх нь.

Плевицкаягийн урилгын тухайд Шарль төдийлөн сүйд болсонгүй.

-За яахав, Озуар-ла-Ферьер сайхан газар.

-Ийм танилтай байхад чи дургүй байна уу?

Шарль инээв.

-Хатагтай Плевицкаятай танил байхыг юу гэж дургүйцэхэв. Харин нөхөр нь дэндүү сайхан ноёнтон.

Вика бас инээд алдав. Тэрээр хар хүндээ хардах шалтаг гаргадаггүй, өөрөө ч нөхрөө харддаггүй билээ. Ямар бэртэгчин биш. Гэхдээ Шарлийн үгнээс ямар нэгэн сэрэмжлүүлэх амьсгаа сэнхийж байна. Цагаачдыг Нелли гуйлгачин гэж байсан, Шарль арай л өөр санаа хэлэх гээд байх шиг.

-Хэрвээ очих хэрэггүй гэж чи үзэж байгаа бол би тийшээ очихгүй шүү.

-Чи урилгыг хүлээж авсан, чамайг авах гээд ирнэ, ийм болсон хойно татгалзах чинь эелдэг бус явдал болно. Гэхдээ долоо гэхэд буцаж ирсэн байхыг бодоорой. Би Прагаас утасдана.

Шарль тэр оройдоо Прага руу гурав хоногоор явж байгаа билээ.

Маргааш нь, өглөөний арван цагт хаалгачийн тэндээс Скоблин Вика руу утасдав.

Вика доошоо буулаа.

Орцны үүдэнд шинэ “пежо” зогсож байв. Вика машины төрлийг хэдийн ялгадаг болжээ. Скоблин түүнийг арын суудалд суулгаад, өөрөө жолоодон, эхлээд хотын энэ зуурын танил гудамжаар явж байснаа тэгсхийгээд хотоос гарав бололтой. Скоблин өөрийн бодолд автан, хөрзгөрдүү царайтай явна. Мэдээжийн хэдэн юм асууж, заримдаа ямар газар яваагаа нэрлэхээс өөр юм эс ярина. Жуанвиль гэдэг жижигхэн хот, Шампаны энэ тэр гэж нэрлээд Венсений ойд 1935 оны хоёрдугаар сарын 27-нд тэдний машиныг ачааны машин мөргөсөн газрыг үзүүлэв. Машин нь будаа болсон хэдий ч, мөргөнгүүт тэр хоёр машинаасаа зам руу хол шидэгдэж амьд гарцгаажээ. Надежда Васильевна яльгүй цочирдож, ойр зуурхан хөх няц авсан, долоо хоногийн дараа концертоо тоглож эхэлсэн, харин мань хүний баруун эгэм хугарч, далных нь яс цуурчээ.

-Тэгээд бүгд сайхан эдгэрсэн гэж Скоблин өгүүлэв. -Заримдаа, тэнгэр муухай үед эгэм, дал хоёр жаахан шархирна, гэхдээ Надежда Васильевна намайг өвчнөө нууж байна гэдэгт эргэлзэхгүй өөрөө иллэг хийдэг юм.

Энэ бол түүний хэлсэн хамгийн урт өгүүлбэр. Скоблин түүнийг хүүхэн хүнийх нь хувьд огт сонирхохгүй байгааг Вика шууд ойлгов.

Озуар-ла-Ферьер замд таарсануудтай адилхан жижигхэн тохилог хот ажээ. Гудамж нь нарийхан, голдуу хоёр давхар барилгатай, жижигхэн тагтнууд нь угалз бүхий ширмэн хашлагатай, зарим байшингийн нэгдүгээр давхарт мухлаг, ресторан энэ тэр байна. Хотын захад өндөр цагаан сүм байна. Скоблин түүнийг “Гэгээн Петрийн сүм” хэмээн тайлбарлаад, арав хүрэхгүй минут яваад хүрнэ гэж мэдэгдэв.

Скоблины хоёр давхар байшин хошуурч нийлсэн, нарийвтар хоёр гудамжны уулзвар дээр байдаг аж. 345 гэсэн дугаартай нүүрэн талаараа маршал Петений гудамж руу харжээ. Саарал чулуун ханатай, том том цонхтой, вааран дээвэрт нь задгай зуухны яндан харагдана. Бетоныг хээлж хийсэн хашаагаа бут сөөгөөр эмжжээ. Ногоон зүлгэн дундуур улаан туйпууны үртсээр нягтруулж өнгөлсөн явган зам гаргасан нь нүднээ чимэгтэй. “Ямар гоё юм бэ, яггүй мөнгө гаргасан байх даа?” гэж Вика бодов.

Скоблин машинаа хаалганы гадаа орхиод Викад найр тавин оруулж, тэр хоёр бяцхан саравчтай довжоон дээр гарлаа. Үйлчлэгч хүүхэн хаалга нээж өгөхөд, түүний гар доогуур хоёр нохой эзэн рүүгээ ухасхийлээ.

-Энэ бол Юка гэж Скоблин хар нохой руу зааснаа, -цагааныг Пусик гэдэг юм хэмээв.

Урт хүлхгэр дашинзтай Плевицкая үүдний өрөө рүү ирж, нөхрөө үнсээд, бас Викаг үнсэж зочны өрөө рүү дагуулан оров. Скоблин дээд давхар руу гарав.

-Коленька, одоо кофе ууцгана шүү гэж Плевицкая нөхөртөө сануулав.

Нэгдүгээр давхрын баруун хагас тэр чигээрээ зочны өрөө. Хэдэн буйдан дээр баахан муур хэвтэж байна, нэг хар алаг муур зөөлөн сандал дотор тухалчихаж. Том ширээ, хананы задгай зуух, төгөлдөр хуур. Цонхнууд нь шараар будсан хоёр хоёр хавтсан хаалттай аж. Цонх нь шар хөшигтэй, буйдан, сандал энэ тэр нь бас шар бүрээстэй байхыг үзвэл Плевицкая энэ өнгөнд дуртай бололтой.

“Дараа ирэхдээ шар сарнай авчрах юм шүү” гэж Вика дотроо товлов. Байшин дотроо бодвол гаднаасаа чинээлэг харагдаж байна гэж бас бодож амжив.

Ханан дээр зөндөөн олон гэрэл зураг хаджээ. Плевицкая ханцуйгүй дашинзтай, аян замын хувцастай, зуны цамцтай, дэлхийн янз бүрийн оронд шүтэн бишрэгчидтэйгээ, папах малгайтай, дайзтай черкеск өмссөн лут өндөр генерал-Врангелийн хөрөг, бас генерал Миллер, генерал Кутепов, за тэгээд, хамгийн ил газар Шаляпин, Собинов, Рахманинов, Бельмонт нарын “Эрхэм хүндэт Надежда Васильевнад”, “Алдарт Надежда Васильевнад” гэх мэтийн дурс-галын гарын үсэгтэй хөрөгнүүд...

-Миний найз нар. Би эд нарыг харна, эд нар намайг харцгаана хэмээн Плевицкая инээмсэглэв.

Суманд нэвт нэвт буудуулсан корниловын хорооны хар улаан тугийг нэг буланд хүндэтгэлтэй байрлуулжээ.

-Николай Владимирович корниловчуудын командлагч гэж Плевицкая бахархан өгүүлэв. - Тийм хүмүүсийг мэдэх үү?

-Тун барагтай даа, дунд сургуулийн түүхийн сурах бичгээс цаашгүй гэж Вика үнэнээ хэлэв.

-Николай Владимирович хорин тавтай, ахмад цолтой байхдаа 1919 оны арван нэгдүгээр сард Корниловын хороог хүлээж авсан, тэгээд 1920 оны тавдугаар сар гэхэд генерал цолтой болчихсон, Корниловын дивизийг командалж явсан юм. Манай хүн командлагч, би нялх биетэй командлагчийн авгай... Цагаан армийнхан бүгд Коленька шиг байсан бол өдийд большевикууд засаг барьж байхгүй л байсан даа.

Үйлчлэгч хүүхэн, нэр нь Мария гэдэг юм байж, кофе, сүү, жигнэмэг авчирч өгөв. Бас шил улаан дарс оруулж ирээд хундагаа хүн бүрт тарааж тавив. Скоблиныг цүнх барьсаар бууж ирэхэд, бүгдээрээ ширээ рүү сууцгаалаа. Хоёр нохой нь тэрүүхэнд хошуугаа хөл рүүгээ шаагаад хэвтээд өгч.

Николай Владимирович юу ч хэлэлгүй, кофегоо шалавхан уучихаад, босч Плевицкаягийн духан дээр үнсээд, цүнхээ авч Вика руу мэхсхийв.

-Уучлаарай, би яарч байна.

-Коленька, бушуухан эргэж ирэхийг бодоорой гэж Плевицкая хойноос нь өгүүлснөө, Вика руу эргэж, -За, ингээд та бид хоёр хоюулхнаа үлдэх нь энэ гэв.

Тэгээд шилтэй дарсаа авч Викагийн жүнз рүү хандуулсанд, Вика,

-Баярлалаа, өглөөгүүр дарс хэрэглэж заншаагүй юм хэмээн талархав.

-Өглөө, орой ямар ялгаа байна, франц дарс сулхан, ус л гэсэн үг, би дуртай уудаг юм гээд өөртөө хундагалж, талд нь ортол зал-гилснаа, -За, Москвагийн тухай яриад бай даа гэв.

-Юу яримаар юм бэ дээ? хэмээн Вика инээмсэглэж дал мөрөө хавчив. -Саяхан метро ашиглалтад орсон.

-Метро гэж Плевицкая зэвүүрхэв. -Парист метро бий болсоор даруй гучин долоон жил болж байна.

Тэрээр нэгэн муурыг дуудаж өвөр дээрээ суулгав.

-Би Москваг их санадаг юм, Вика минь... Би эхлээд “Яр”-т дуулдаг байлаа, нэг сайхан ресторан байсан юм. “Яр”-ын захирал Судаков, энд худалдаачид эхнэртэйгээ байцгаагаа, тийм учраас завхай байж болохгүй гэх ухааны юм яриад, жүжигчдийг тайзан дээр их нүцгэлж гарахыг зөвшөөрөхгүй, завхай гэх юм юу байхав, харин би Москвад их амжилт олсон, москвацийнхан надад хайртай болцгоосон. Москвагаас Доод Новгородын яармагт очдог байлаа. Нэг удаа очиход маань Леонид Витальевич Собинов анзаарч, надад баглаа сарнай бариад, “Та бол авьяас” хэмээж, Дуурийн театрт, өөрийнх нь концертод оролцож дуулахыг урьсан юм. Энэ дивангарын явдал, хонгор минь, хэзээ тэгсэн гээч, 1909 онд.

Тэрээр хундагатай дарсаа гүйцээчихээд, бодосхийснээ дахин хундагалав.

-Манай москвагийнхан ч ёстой сайхан даа, би тэдэндээ ёстой хайртай, дуу хоолой нь шимтэй, жинхэнэ тансаг орос аялгуу. Тэднийг петрбургийнхэнтэй зүйрлэхийн арга байхгүй, цаадуул нь франц хэлийг оросоосоо илүү мэднэ. Хэдэн хүүхэн нэг удаа над руу театрын дурангаа онилчих нь тэр. Эд бараа л харж байна гэсэн үг. Нэг нь асууж байна: “Түүдэг гэж юу юм бэ, бэрээ гэж юу юм бэ?” Миний бүр дургүй хүрээд явчихлаа, нүд рүү нь зэвүүрхэн харж байгаад хэллээ: “Бэрээ гэдэг бол нөхөр нь гэм хийсэн авгайгаа сургадаг торлог... Түүдэг гэдэг нь бол утас ээрэх гэж бэлтгэсэн олсны самнамал бөөндгий...”

Тэр авхай дахиад намайг дурангаараа харж байна: “Charmant. Та их ялдамхан байна!”

Энэ дээдсүүд л Оросыг хөнөөчихсөн юм. Ард түмнээ ад үзнэ, тэгээд хариугаа авах нь тэр дээ. Танд гэж хэлэхэд, би энд ч гэсэн тэр авхай нараас холхон байдаг юм. Дурантайгаа л үлдсэн байх, түүнээс биш, бийгээс бие, бэлчихээс бөөс гэгч болсон хүмүүс... За тэдний тухай ярихаа больё, миний уур шагчихдаг юм.

Тэгээд дарснаас дахин хундагалав.

-Нэртэй болсныхоо дараа би Москва руу шилжсэн юм. Дегтярнын хөндлөн гудманд сайхан байр авсан, түүнийг засч тохижуулах хооронд Их Дмитровкад тавилгатай өрөөнд сууж байлаа. Хаа байдгийг мэдэх үү?

-Мэдэлгүй яахав. Их Дмитровкаг ч мэднэ, Дегтярнын хөндлөн гудмыг ч мэднэ.

-Тэр өвөл цас их орсныг яана, гуравдугаар сар гарчихаад байхад чинь цас ороод л байдаг, жавартай салхинд хөлдөхөөс сэргийлж гудамны модыг хучна, манай ганган Москва, яахав дээ, цасан баринтагтай мөнгөлөг хатан л гэсэн үг.

Вика энэ тансаг ярианд балмагдан, кофеныхоо чихрийг хутгаж байгаа хүн болж, хараа буруулав.

-Би хэзээнээс нааш өвлийн Москвад л илүү дуртай, өвлийн амьдрал арай л хөгжилтэй юм шиг санагддаг сан, амьтан хүн зүг зүгтээ яараад, дэлбэгч нар ташуураа агаарт тас тас даллан, морьдын хонх жингэнээд л... Маний нас сүүдэр ч тэр л хурдан чарга шиг жирэлзэж одох юм, тэгээд ч тэр юм уу, Москва эртэн цагийн сайхан зүүд шиг сэтгэл зүрхэнд уяатай... Петербург ч бас уяатай, Хааны Тосгон бас, би тэнд Эзэн хаандаа ая барьж байлаа шүү дээ гээд Плевицкая чимээгүй болж инээмсэглэв. Хэлсэн зүйлийг нь Вика тогтож ухаараг гэх аястай тийнхүү түр азнаж цонхоороо харжээ. -Би тэгэхэд нүгэлтэй сандарсан, аяга кофе, жүнз коньяк гуйж уулаа, хорин дусал бамбайн ханд хүртлээ... Тэгээд эзэн хаан руугаа гарах нь тэр дээ. Бөхийхөөрөө бөхийж мэхийн ёслоод, нүүр рүү нь шууд харсан чинь хааны цоглог нүднээс гэрэл сацарч байх шиг санагдаад явчихлаа. Айдас тэр даруй хийсэн арилж, сэтгэл сайхан уужирлаа. Би тэгэхэд мөн олон дуу дуулсан даа. Эзэн хаан хүртэл намайг ядраагүй биз? гэж асуусан гээд л бод. Би юун ядрах тухай бодохов, хүн болж төрсний хэрэг бүтэж байх шиг аз жаргалтай байгаа юм чинь. Толгойд орж ирснээ л дуулаад байлаа. Харчуулын хувь тави-лангийн тухай дуулсан, тэр ч бүү хэл, Сибирийн тухай нэг хувьсгалт дуу дуулсан. “Би орь залуу охин явлаа”-

г дууллаа. Дэлбэгчийн тухай бас дууллаа. Тэр дууг та мэдэх үү?

-“Эрэмгий гурвалсан чарга эрчилж явна” бил үү, эсвэл “Өртөөчний гурвалсан чарга хурдалж явна”... гээд үү?

-Үгүй ээ, би Эзэн хаанд өөр дуу дуулсан юм. Плевицкая хундагаа ширээн дээр тавьж, толгойгоо өлийсхийн тухлаж байгаад аяархан аялах нь тэр:

Харвасан сум лугаа адил

Агсам гурвал довтолгоно.

Төрөлх Москва минь үүрд баяртай гэх

Түрлэг ая дуу тэндээс цууриатлаа.

Алтан ганжирт чамайгаа би

Ахиж хараа ч уу, үгүй ч үү,

Азай буурал Кремлийнхээ хонхыг

Ахиж сонсоо ч уу, үгүй ч үү,

Нарт хорвоод үүрдийн юм гэж үгүй

Намайг аваад хувь заяа минь алсаллаа.

Эхнэр минь баяртай, үрс минь баяртай

Эргэж ирэх эсэхийг эзэн бурхан л мэднэ.

Уур савсуулан гурвал чарга зогслоо,

Улаач нүд юүндээн алчуураа хүргэлээ.

Тэгтэл энгэр дээр нь гэнэт

Тэвгийн чинээ сувдан нулимс уналаа.

Тэгэхэд эзэн хаан “Наад дуунаас чинь миний хоолой зангираад явчихлаа” гэж айлдсан шүү.

Эзэн хаан орос дууг ингэж л мэдэрч байсан юм. Надтай салах ёс гүйцэтгэхдээ, миний гарыг чанга гэгч нь атгаж, “Надежда Васильевна, танд баярлалаа. Таныг сэтгэл дүүрэн сонслоо. Таныг дуулах сургууль тухайлж хийгээгүй хүн гэж надад хэлсэн. Тэгвэл битгий хийгээрэй. Байгаагаараа л байгаарай. Би сургууль хийсэн гургалдай хоолойтнуудыг бишгүй сонсож явлаа. Тэд нар бол сонсголд зо-риулж дуулдаг юм, харин та бол сэтгэлд зориулж дуулж байна” гэж хэлж билээ. Вика минь, миний амьдралд ямар аз жаргал тохиосон байна даа,

Эзэн хаанаас өөрөөс нь ийм цаглашгүй үнэтэй үг сонсоно гэдэг чинь?

-Ёстой, ёстой хэмээн Вика амыг нь дагуулах зуур шилтэй дарс дундаа орсныг анзаарав.

-Хааны Тосгонд би Эзэн хаанд олон удаа дуулж өгсөн, би ч түүнд дуулж өгөх дуртай, хаан ч намайг сонсох дуртай. Бас надтай ярих ч дуртай, гэтэл намайг Эзэн хаантай ярилаа, ярихдаа гараа савчууллаа энэ тэр гэж ордныхон гоморхдог, зэмлэдэг байсныг яана. Хаан бол намайг зэмлэхгүй, намайг дээдсийн хүрээлэнгийн зан аягт суралцаагүйг ойлгодог байсан. Тэгтэл тийм хааныгаа алчих юм! Үүнийг би энэ яваа насандаа өршөөхгүй! гэж Плевицкая заналтай хэлээд, царайд нь хорсол тодроод ирэв. -хэнийг ч уучлахгүй! Эзэн хаан Москвад жинхэнэ орос хүмүүсийн дунд аж төрж байсан бол ямар ч хувьсгал гарахгүй байсан, орос хүмүүс эцэг болсон хаанаа доромжлуулахгүй шүү дээ... Москвад болсон Бородиногийн баяр ёслолыг санаж байна. Гудамж талбай хүнээр дүүрчихсэн, хүмүүс дуулах нь дуулж, бүжих нь бүжээд л... Кремлийн сүмийн алтан ганжир, алтан загалмай наранд гялалзаад л... Их Иваны аврага хонх дүнгэнэн, Москвагийн тоо томшгүй олон хонх даган түрж хангина-хуйд газар чичрэх шиг болж, тэр өдөр Москвад байсан бүх хүний нүднээс нулимс бөмбөрсөн дөө. Петербургт тийм баяр байж болох уу? Тэднийхэн дандаа язгууртан, үндэс яривал, германчууд, скандивчууд гээд гүйцээ, тийм учраас л түмэн хараал идэж ханашгүй тэр хувьсгалыг сэдэхгүй юу.

Жинхэнэ орос хүн чинь ёстой Шаляпин даа. Мамонтов намайг түүнтэй танилцуулсан юм. Федор Иванович надад, “Төрөлх дотно Надюша минь, Бурхан чамайг ивээх болтугай, газар шорооноосоо авчирсан өөрийнхөө дууг л дуулж яваарай, надад тийм дуу байхгүй, би хөдөөнийх биш, төв газрын хүн” гэж хэлж байсан юм. Нээрэн, олон сайхан, ухаантай хүнийг бурхан надад заяаж дээ.

Цонхон дор азарган тахиа чангаас чанга донгодов.

Вика санаандгүй байсан болохоор овсхийтэл цочив.

Плевицкая инээд алдав:

-Манайх чинь зөвхөн нохой, мууртай айл биш, бас тахиа бий. Коленька өөрөө гардан тэжээдэг юм гээд босч, -Намайг сонсох гэж чилж байгаа байлгүй, залхааж гүйцсэн байхаа гэж өгүүлэв.

-Өө, хаанаас даа. Та ямар гоё ярьдаг юм бэ гэсээр Вика бас бослоо.

Манж үг биш. Викад үнэхээр сонирхолтой байж. Эзэн хаантай гар барин мэндэлж явсан энэ гурван жилийн боловсролтой тариачин хүүхэн, хожмоо хувьсгалд ниргүүлэн толгой хоргодох газаргүй дүрвэгч болж хувирснаа дахиад даян дэлхийд нэр нэндэн манджээ. Хувь заяа гэгч энэ бус уу?

-За, тийм бол баярлалаа... Явья, би танд байшингаа үзүүлье, дараа нь хоюулаа цэцэрлэгт жаахан сууцгаая.

Зочны өрөөнөөс дугуй шатаар хоёр дугаар давхар руу өгсөх зуур нарийхан цонхны дэргэд Плевацкая Викагийн гараас барьж,

-Харж байна уу, яг тэндээс цааш ой байна гэснээ цонхны шилэнд нүүрээ бараг наах шахан, - Энд Колягийн гараашийг тулгаад барьчихсан юм, машинтай бол гарааш заавал хэрэгтэй гэв. - Өөр нэг эвтэйхэн юм юу гэвэл гал тогоо руу гаднаас шууд орж болно. Мария өглөө ирэхэд, бид чимээ авиа огт сонсохгүй шүү дээ. Ер нь бол би эрт босдог юм, харин заримдаа элдэв бодол толгойд эргэлдээд нойр хулжчихна, эсвэл дөнгөж өглөөний долоо хавьд сая нэг юм унтана.

Скоблины ажлын өрөөнд номын шүүгээ байна. Франц номнууд нэг хэсэг тавиур дээр, орос нь нөгөө нэг хэсэг дээр байна: Тургенев, Достоевский, Толстой...

-Би уул нь Толстойг унших дуртай байсан юм. Гэтэл “Тамыг нурааж дахин сэргээсэн нь” гэдгийг уншсанаас хойш гартаа ч барихаа больсон. Хорлогчинтой өвгөн, бүх хүнийг шүлсээрээ булж, хүн амьтныг толгой дараалан зүхнэ, ганц ухаантай нь юм гэнэ, би тийм зохиолоор яах вэ дээ?

Тэр өрөөний ханаар бас баахан хүний хөрөг өлгөчихөж: Куприн, Бунин, Керенский, өдий төдий генерал, офицер.

-Эд нар бүгд манай корниловчууд... Коленька таван зуун тулалдаанд оролцсон, олон удаа шархадсан, корниловчууд амь насаа хайрлана гэж ёстой байхгүй, бусад нь бүгд корниловчууд шиг тулалдаж байсан бол ч...

Эрх чөлөө, Орос орныхоо төлөө

Эрс тулалдаанд дуудах аваас

Эрэлхэг зоригт корниловчууд

Эргэж хургалгүй гал, ус руу орно.

Плевацкаягийн нүдэнд нулимс гүйлгэнээд ирлээ.

-Хөөрхийс минь, хөөрхийс минь... Жинхэнэ баатрууд. Перекопт би бүр ухмал шуудуунд дуулж явлаа. Большевикуудын үхэр буун дуу нүргэлж байхад хүртэл би дуулсаар л байлаа. Гэвч бүтээгүй, санаснаар болж өгөөгүй...

-Одоо би чамд нэг юм үзүүлье... Тэрээр Викаг гэнэтхэн “чи” гэнэ, тэгснээ буцаад л “та” гэнэ. Тонгойж байгаад, нэг их зузаан биш, гэхдээ ердийн номноос арай том нэг ном гаргаж ирээд хавтсыг нь нээснээ Вика руу дохиж, “Зэрэгцээд суу, бүү ай, шал цэвэрхэн байгаа” гэв. -Харж байна уу, Надежда Плевацкая-“Дёжкийн Карагод”... Нэр нь ойлгомжтой юу? Дёжка гэж би, Надежда. Намайг манай гэрийнхэн Дёжка гэдэг байсан юм. Карагод гэдэг нь манай нутгийнхаар бол, Курскийнхээр шүү дээ, тойрон бүжиг. “Титэм” хэмээсэн өмнөх үг нь Алексей Ремизовынх. Надад бол их нэр төр!.. Харин Москвагийн та нар бол тийм овгийг ч

мэдэхгүй, танайд Ремизов гэж бас хориотой нэр, энэ хүн хорин нэгэн онд Оросыг орхин одсон юм... За, миний муу ээж энэ байна... гээд Тэрээр зурганд уруулаа хүргэв. -хүний дээд, хүний хайлан ээж минь, диваажиндаа жаргах болтугай... За, энэ миний залуугийн зураг байна. Шөнтгөр хамартай тариачин охин Дёжка, би яг хэвээрээ шүү. Энэ бол дахиад би байна. Ийм ханцуйгүй даашинзтай концерт тоглодог байлаа. За, номын хоёрдугаар хэсэг, “Миний дуулсан замнал”, энэ нь бүр хожим, гучин онд нийтлэгдсэн юм. Рахманинов өөрийнхөө “ТАИР” гэдэг хэвлэлийн газарт, өөрөө хэвлүүлсэн гээд л бодчих. “ТА” гэдэг нь Татьяна, “ИР” гэдэг нь Ирина гэсэн үг, хоёр охиных нь нэр. Энэ би тосгонд байна, дахиад ээжийн зураг. Энэ номонд миний бүх амьдрал бичээтэй байгаа. Би танд уншуулна. Гэхдээ яг энийг өгөхгүй, энэ бол минийх, би хэнд ч өгдөггүй юм, хаана нууж байдгийг харж байгаа биз дээ? гээд Тэрээр инээв. -Яг л доржпалам хадгалж байгаатай адил... Надад өөр хоёр хувь бий, танилууддаа өгч уншуулдаг юм, одоо хүний гар дээр байгаа, авчрахаар нь танд өгье.

Плевицкая даруухан тавилгатай дараачийн өрөөний хаалгыг онгойлгосноо, “Хоноцын өрөө” гэж тайлбарлав.

Унтлагын өрөөний ханан дээр корниловынхны дүрэмт хувцастай Скоблины бүтэн хөрөг байна. Энгэртээ Георгийн загалмайт одонтой эрэлхэг царайтай дэгжин офицер.

-Хорин онд бид анх танилцахад Коленька ийм байсан юм,

улаантны эсрэг байлдаан үргэлжилж байсан цаг. Бид хоёр Туркийн Галлиполи хотод гэрлэцгээсэн юм. Хуримаа даруухан хийсэн, корниловынхны хэдхэн офицер байсан, генерал Кутепов мөргөсөн эцэг болсон... Хөөрхий муу Александр Павлович, түүнийг большевикийн эрлэгүүд олзолж аваачаад, зовоож, тарчлааж алсан...

Плевицкая нулимс унагалаа. Жижиг шүүгээ нээж, шилтэй коньякноос бяцхан жүнзэнд хийж уучихаад буцааж хийв.

Унтлагын өрөөний цаана нуман хаалгатай бяцхан өрөө байна. Жижигхэн ширээ, дэргэд нь зөөлөвчтэй исэр, номын тавиур, хувцасны өргөн шүүгээ, том толь.

-Миний өргөө хэмээн Плевицкая алиалав. -Би энэ байшинд дуртай, анх харангуут л аятайхан санагдсан, тохилог, гэрэл гэгээтэй саруулхан, хойшоо, баруун, тийш, зүүн тийш гээд гурван тал руугаа цонхтой, бид нар мандахыг ч харна, жаргахыг ч харна. Би харанхуйд байж сууж чаддаггүй юм. Бас ганцаараа байх их дургүй. Та гар мараа угаах уу? Онгоцны өрөө энэ байна шүү.

Тэр хоёр хувцаслаж, цэцэрлэг рүү гарлаа. Араас нь ноход, нохдын араас муур даган цувцгаав. Байшингийн гадуур хэдэн тахиа явж байна.

Вика, Плевицкая хоёр гурван хусны дор тавьсан сүлжмэл сандалд сууцгаав. Хэдийгээр хоёрдугаар сар ч гэсэн нар ээвэрлээд дулаахан байна.

-Энэ хуснууд, харж байгаа биз, би өөрөө суулгасан юм.

Мария гал тогооноос гарч ирэхэд, Плевицкая ширээ рүү харцаараа заалаа. Мария байшинд ороод, нөгөө шилтэй дарс, хоёр хундага, аягатай самар авчирч ширээн дээр тавив.

-Манай энэ ухаалаг шүү, Мария Чека гэдэг польш хүүхэн, гэхдээ Францад өсч бойжсон юм, бид хоёр францаар л ярина, ер нь, үнэнээ хэлэхэд, би польш хэлэнд дургүй, “пше”, “пши” гэж шаагиад ярьж байна гэж хэлэхэд бэрх, түүнээс гадна Зержинский, Менжинский гээд Улс төрийн газар тэр чигээр польшууд.

Плевицкая хоёр хундаганд дарснаасаа хийв.

-За, оросын хусны дор ч та ууж л таарна даа.

-Өө, тэгэлгүй яахав хэмээн Вика инээмсэглэв.

-Оросын төлөө!

Хундагаа тулгацгаав.

-Бид энэ байшинг 1930 оны тавдугаар сард Шнейдерийн товчооноос худалдаж авсан юм хэмээн Плевицкая үргэлжлүүлэв. -Энэ хавьд оросууд олон бий. Дээр үед энд ой байсан юм гэнэ лээ, модыг нь хуу булгалаад байшин барьж эхэлсэн гэж байгаа, харин би бол хус суулгаад байгаа юм гээд Тэрээр хусаа илбэж, хоолой нь чичирсхийв. -Миний муусайн хуснууд, хус харахаараа л Курск нутаг, төрөлх Винниково тосгоноо, тэр хавийн хусан төглөө санадаг юм... Би яасан шүү, Вика, нөгөө Староконюшенный танай байрыг санасан шүү...

-Тийм, та ярьж байсан.

-”Каролина”-д байхад би тун итгэл муутай хэлсэн, нэг юм бүдэг бадагхан санах ч шиг, үгүй ч шиг байсан, харин дараа нь танай эцэг, эх хоёрыг тов тодхон санасан шүү. Гэхдээ би өөрийгөө шалгаж үзмээр байна, надад нэг юм хэлж өг, танай хаалган дээр “Профессор Мурасевич” гэж гоёмсогоор бичсэн бяцхан зэс пайз байсан уу?

-Марасевич гэж Вика залруулав. -Байсан, тийм пайз байсан.

-Аав, ээж чинь амьд сэрүүн үү?

-Ээж хорин хоёр жилийн өмнө өөд болсон, аав маань жар шахаж яваа, би санаа зовох л юм.

-Жар чинь нас биш хэмээн Плевицкая эрсхэн өгүүлэв. -Тэгэхээр санаа зовох хэрэггүй, муу ёрлох хэрэггүй, Бурханы авралаар энх тунх аж төрнө. Юуш дээ, Вика, намайг танайх руу Станиславский аваачсан юм... Би танайд дуулж байлаа... Орос маягаар элбэг дэлбэг дайлаад, тохилог, сайхан байсан даа... Намайг Станиславский авч очиж байгаа, тэгсэн чинь би Ключевийг дагуулаад хүрдэг байгаа даа. Яруу найрагч Ключев, тийм хүнийг мэдэх үү?

Вика түгдэрсхийн саатав.

-Их дөлгөөн хүн байж билээ хэмээн Плевицкая үргэлжлүүлэв. -Байсхийгээд л уйлна. Миний

хамгийн дуртай, түүний нэг шүлгээс уншиж өгье гээд сандлынхаа арыг налж нүдээ анив:

Бараан цамцаа хайш хэдрээд

Бүүдгэр дэнлүүг дагана аа, би

Цайлган өхөөрдөм царайлсаар

Цаазын тавцанд очно оо, би

Гэх мэтээр... Харин өөрөө бол бараан биш, цорын ганц хөх эрээн цамцтай, бас бараг зулгаараа эргэчихсэн нэг муу савхин гуталтай, би нэг шинэ гутал бэлэглэхэд мань хүн авсан, ер нь юм өгвөл авна, харин гуйна гэж байхгүй. Гараа палтоныхоо ханцуй руу зөрүүлж хийчихээд, байгаа байхгүй нь мэдэгдэхгүй нам гүм сууна, хэрвээ яривал ухаалаг, бас өрөвчхөн юм хэлнэ... Хөөрхий муу найз Колюшка минь одоо хаахна яваа бол доо? Эндхийн сонинд бичсэнээр бол тэр маань баригдаж, Сибирьт цөлөгдсөн юм шиг байна лээ, хөөрхий амьтан балраа биз. Энэ хорвоог зовж дуусгах совин нь татаад уйлдаг байсан ч юм бил үү?.. Танд хүйтэн байна уу?

-Үгүй ээ, зүгээр.

-Тэгсэн ч гэсэн хоюулаа жаахан алхая.

Тэр хоёр гудамж руу гарлаа. Хаа нэгтээ зөрөх хүн Плевицкаятай мэндэлж байна.

-Энд бараг хоёр зуугаад орос айл байдаг юм. Амьдрал Заяагч Гурван Гэгээн Эх Дагинын сүм манайд бий. Голчлон Николай Владимирович бид хоёрын хандивласан хөрөнгөөр хэдэн жилийн өмнө барьсан юм. Тийм учраас би хүндэт ивээгч нь.

Тэр хоёр ганц давхар байшин руу ирэв. Шувуун нуруун дээр нь загалмай хатгасан, нүүрэн талдаа бурхны зурагтай энэ байшин нөгөө сүм нь юм байж. Дотор нь дуу чимээ алга, баахан зул асч байвч бараг харанхуй гэмээр. Ханаар нь бурхны хөрөг.

Плевицкая тэртээ доош тонгойн мэхийгээд, загалмай руу очиж үнссэнээ, хэдэнтээ загалмайлан залбирч, амандаа уншлага шившлээ. Вика түүний хийсэн болгоныг нь яг дуурайн давтсан боловч сэтгэл өчүүхэн төдий ч хөдлөсөнгүй. Яаж шон шиг ёрдойгоод байх вэ гэсэндээ л тэгж. Ер нь сүмд анх удаагаа орж байгаа нь энэ болж таарав. Жааханд нь томчуул дагуулж орж байсан байж мэднэ, гэвч өөрт нь санах юм алга.

Харин Плевицкая үнэнхүү сүсэглэн мөргөлөө. Гарсан хойноо,

-Талийгаач ээж минь намайг жаахан байхад, “Сүм дотор мөргөл залбирлаас өөр бодол байх ёсгүй. Чи бурхны өмнө өргөсөн зул шиг л зогсож байх ёстой” гэж сургамжлан захидагсан. Хөдөөний, бичиг, номгүй, жирийн авгай мөртлөө, “Бурхны өмнө зул шиг” гэж мөн мундаг юм хэлж байгаа юм шүү гэж ярив.

Чимээгүй хэд алхалснаа Плевицкая яриагаа үргэлжлүүлэв.

-Би сүмд ч дуртай, хурал мөргөлд ч дуртай. Та нар чинь тэр Оростоо Бурханаа мартчихаад байгаа, аягүй бол чи ч мартсан байлгүй?

Тэрээр Викаг сонжих мэт харав.

-Тэгсээн, биднийг сүсэг бишрэлгүй болгож хүмүүжүүлсэн гэж Вика үнэнээ хэлэв.

-Муу байна. Сэтгэл зүрхэндээ Бурхангүй амьдарч болохгүй.

Автобаазын даргын нарийн бичгийн дарга хүүхэн чиглэл авчихсан тул Сашагаас паспортыг нь нэхэж аваад, “Жолооч нарын бүрэлдэхүүний бүртгэл” гэсэн том зузаан дэвтэрт овог, нэр, төрсөн он зэргийг хуулж бичээд, ямар боловсролтойг нь асуухад Саша “дунд” гэж хариулав. Эцэст нь, сүүлчийн ажлын газрын тодорхойлолтыг нь шаардав.

-Бусад бичиг баримттайгаа хамт алдчихсан гэж би танд хэлсэн шүү дээ.

-Тэгвэл ажиллаж байсан газраа бичүүлчих.

-Би тийш нь захиа бичнэ, тэгээд тэд тодорхойлолт ирүүлнэ гэж Саша зувчуулав.

Хүүхэн онгорхой хүснэгт орхих ёсгүй, бүртгэлийн бүх хүснэгт бөглөгдсөн байх ёстой учраас хэсэг зуур бодлогошров.

-Тодорхойлолт ирүүлсэн дор нь надад авчирч өгнө шүү.

-Заавал өгнө.

Хүүхэн сүүлчийн хүснэгтийг харж,

-Хаяг? гэснээ паспортыг дахин нээж үзэв. -Та суух газраа бүртгүүлээгүй юм байна. Ийм хүнийг авах эрх надад байхгүй.

-Намайг дотуур байранд оруулах болов уу гэж бодсон юм.

Хүүхэн босч, дарга руу ороод, буцаж ирэв.

-Дотуур байранд сул зай байхгүй.

Ойлгомжтой. Ёстой үйл үзэж, шар махтай хатаах нь ээ.

-Би өнөөдөр өрөө хөлсөлж авна, тэгээд хаягаа паспортон дээрээ бүртгүүлчихээд, ирж мэдэгдье гэж Саша хэлэв.

Нарийн бичиг хүүхэн дахиад бодлогошров. Эргэлзэж байгаа нь илт. Ажилд авахгүй байх бэлэн шалтаг байна. Гэтэл ав гээд тушаачихсан байгаа. Тэгээд яахав гэж толгойгоо зовоож байна.

-Би таныг хөөдөхгүй ээ, та надад итгэ. Би паспортоо танд барьцаанд үлдээчихмээр байна, даанч паспортгүй бол оршин суух зөвшөөрөл өгөхгүй.

Хүүхэн дуугарсангүй.

-За, яахав, тэгье. Та цэргийн бүртгэлээ өгчих.

-Би цэргийн алба хааж амжаагүй.

Хүүхэн түүн рүү өлийн харснаа, дахин босч дарга руугаа оров.

Түрүүчийнхээсээ удаж байна. Цаана нь эргүүлж байгаа бололтой түүний ширээн дээрх салаа утас хэдэнтээ хуржигнав. Захирал нэг тийш нь утасдаж буйг Саша ойлголоо.

Нарийн бичгийн дарга тэгж тэгж ёозгүй царайлсаар гарч ирээд, ширээндээ тухлан сууснаа, Сашагийн паспортыг ойртуулж, “Автобааз №1-д ажилд авав” гэсэн дөрвөлжин тэмдэг дарлаа.

-Хаягийн бүртгэл хийлгэнгүүт хотын цэргийн хэлтэст очиж цэргийн бүртгэлээ авах хэрэгтэй, дараа нь дахиж над руу ирнэ. Одоо инженер рүү оч, тушаал өнөөдөр гарна гэж хэлээрэй.

Леонид энэ удаа ч бас тэвшний цехэд байж таарав. Нөгөө л байдлаараа хана налаад зогсчихож. Глеб бас л багсаа барьчихсан, автобусны дээвэр дээр явган сууж харагдана.

-Сайн уу гэж Глеб хашгирлаа.

Леонид чимээгүй толгой дохиод, асуух янзтай харав.

Саша паспортоо гаргаж, “Автобааз №1...” гэж тамгалсныг харуулав.

-хэнд бичих хэрэгтэйг би чамд зөв хэлж дээ. Чамд сайн машин

өгнө өө. Өнөөдөр хүлээн авч, сайн үзэж хар, маргааш өглөө долоод гарна шүү.

Глеб автобуснаас үсэрч буугаад, гараа арчих зуур,

-Үүнийг чинь угаах хэрэгтэй, ялдам минь. Александр, чи нэг шил юм тавина шүү гэв.

-Би бэлэн байна.

-Людмила, Ганна хоёрын нэгнийд очъё, Людка руу очсон нь дээр, хүн шиг жаахан сууцгаая гэж Глеб ахив.

-Тохирлоо.

Леонид Сашаг механик руугаа дагуулж очив.

Цаадах нь ярвайх янзтай, өөрийгөө Хомутов гэж танилцуулав.

-Энүүнд 49-80-ыг өг гэж Леонид тушаалаа.

Тэр машин саравчин дор зогсож байв.

-Эхлээд үзэж хар, дараа нь актанд гарын үсэг зурцгаана. Одоохондоо ээлжийн хүн байхгүй,

ганцаараа явж бай. Багаж дутуу байвал хэлээрэй, би нэмж өгнө.

Ингэж хэлчихээд Хомутов яваад өгөв.

Багажны цүнх яг байрандаа байсан боловч дотор нь юу ч алга. Ганц манивийл байна. Нөөц дугуй ч алга. Бас аккумулятор нь суучихаж.

Саша энэ бүх байдлыг Хомутовт илтгэв.

-Заяагүй шаарнууд чинь мулзалчихаж. Харж хандахгүй болохоор л ингэж мулзалж байгаа юм гэж Хомутов зүхэлдэв.

Тэгээд гараашийн булан дахь жижигхэн ширээ рүү очиж суугаад, багажны цуглуулга, бэржээхэн бээлий, нөөц дугуй, аккумулятор энэ тэрийг шаардах мэдүүлэг бичиж өгөв. Саша эдгээр зүйлээ онцын төвөггүй гаргуулж авлаа. Гагцхүү сэлбэг дугуй авахад инженерийн гарын үсэг хэрэгтэй, шинэ аккумулятор авахад хуучнаа тушаах ёстой юм байж.

Леонид гарын үсэг өгөхдөө Сашаг хөлөөс нь толгой хүртэл сонжих мэт харав.

-Хамаг хувцсаа барчихна даа.

-Ажлын хувцас тавьж өгөх ёсгүй юм чинь яая гэхэв.

Леонид нэг цаасан дээр: “Агуулахад. Жолооч Панкратовт хуучин эдлэлээс хөвөнтэй хүрэм, өмд хоёр түр тавьж өг” гэж бичээд Сашад өгөв.

-Баярлалаа.

Саша агуулахад очиж, тос дааварласан хөвөнтэй хүрэм, хуучин өмд хоёр олж авав. Зарим газар хөвөн нь цухуйжээ. Тэглээ ч гэсэн Леонидэд чин сэтгэлээсээ талархалтай байв. Ганц пальто, ганц ноосон цамц, ганц бүтэн өмдийг нь энэ ажлын хувцас л аврана.

Саша машиныхаа бүхээгт орж хувцсаа сольж өмсөөд, аккумулятор, нөөц дугуй хоёроо байрлуулж, машинаа асаавал, мотор нь сайхан ажиллаж байж. Хашаан дотуур хэсэг явлаа, араа нь номоороо залгагдаж байна, гар, хөл тоормос хоюулаа сайн барьж байна. Гаргуунд нь хаясан хуучин машин болохоор моторыг нь цэвэрлэх, тослогооны эд ангийг янзалж сэлбэх, арчих цэвэрлэхээс авахуулаад мундахгүй ажил байсан тул Саша ажил тартал машинтайгаа ноцолдов. Дугуйныхаа зээрэнцэгийг будвал зүгээрсэн, дараачийн удаа л болохоос.

Саша урамтай ажиллав. Бичиг баримт нь бүрдэж, номын ёсоор ил хүн боллоо. Одоо оромж олох, оршин суух зөвшөөрөл авах ажил үлдлээ, гэхдээ энэ онцын төвөггүй, харин цэргийн хэлтэс дээр юу болдог бол? Дээд сургуульд байхдаа цэргийн хэрэг үзэж, “цэргээс гадуурх дээд бэлтгэлийг” давсан болохоор цэргийн алба хаах ёсгүй, уул нь дээд сургууль төгссөн бүх хүнд бага даргын цол өгдөг байсан, одооныхоор бол дэслэгч. Гэхдээ мань хүн цол аваагүй, тийм учраас цэргийн хэлтэс дээр ямар хэрэг мандахыг эс мэдэх тул тийшээ очих гэж яарахгүй.

Гол юм бол бичиг баримт. Эндээс тонилох хэрэг гарвал шинэ газар очоод паспорт хөөцөлдөх шаардлага алга, паспорт өвөрт нь байж байна, дээр нь ажлын газрыг тэмдэглэчихсэн байгаа.

Михайлов руу очоогүй бол юу ч бүтэхгүй байж. Михайлов түүнийг үнэхээр саналаа гэж үү? Өргөдөлдөө Арбат, 51 гэж Москвагийнхаа хаягийг бичсэн. Эсвэл үүнийг анзаараагүй, зүгээр л өргөдөлд учирласныг, тухайлбал Үндсэн хуулийн дагуу хөдөлмөрлөх эрхтэй гэснийг ойлгож үзсэн байх. Ямар ч байсан зоригтой л хүн! түүнийг Михаил Ефимович гэдгийг Саша гэнэт санах. Тэр махлаг туслах нь ч түүнтэй хамт Арбатад, эцэг эхийнд нь ирж байсан, Саша, Мотя хоёрын шатрыг харж, зүгээр ч үгүй, санаа бодлоо хэлж байсан. Мотя хөндлөнгөөс хүн юм хэлэхэд дургүй, махлаг нөхрийг өөр нүүдэл хэлсэн төдийд, “хүний амаар нүүдэггүй” гээд шатраа нураачихаж байж билээ. Мотя, Михаил Ефимович хоёрын эцэг яг тэр байшиндаа гэрэл зургийн газартай байсан бөгөөд хориод оны дундуур түүнийгээ хаасан юм. Тэр үед энэ тухай юу гэж бодож байснаа Саша одоо саналаа: Михаил Ефимович намын том албаны хүн болохоор эцэг нь жижиг хувийн аж ахуйтан байх нь түүнд эвгүй байсан биз, хувийн аж ахуйтай хүмүүсийг жижиг хөрөнгөтний давхрага гэж үздэг юм чинь. Энэ айл Арбатаас тэгсхийгээд нүүчихсэн учраас Сашагийн тэдний тухай дурсамж үүгээр дуусав. Өөр нэг зүйл: Тэднийх өөр овогтой, Михайлов бол Михаил гэдэг нэрнээс үүсгэсэн намын далд нэр.

Засварын газраас хувцсаа сольсон Глеб хуучин халцархай цүнхээ барьсаар гарч ирэв. Костюмны гадуур нисгэгчдийнх шиг үстэй дотортой савхин хүрэм өмсчээ.

-Ажлаа дуусга, ялдам минь.

Саша багаж хэрэгслээ эмхэлж бэржээхэн цүнхэнд хийгээд хувцсаа

сольж, хөвөнтэй хүрэм, өмд, багажаа агуулахын няравт тушаав.

-Суйлчихна гэж айгаа юу?

-Мулзлуулсан машин, энүүнээс улс юм хумслаад сурчихсан юм байна гэж Саша учирлав.

Дараа нь механик тэр хоёр, жолооч Панкратов. А.П. бүрэн бүрдэлтэй, хэвийн ажиллагаатай 49-80 дугаартай ЗИС машиныг хүлээж авсан тухай актад гарын үсэг зурцгаав. Хомутов машинаа огт харалгүй гарын үсэг зуржээ. Жолооч нь гомдол мэдүүлэхгүй байгаа бол харахын хэрэг юу байхав.

Саша Глебийг Леонидын өрөөнөөс олов.

-Та нар зугуухан явж бай, би гүйцээд очно гэж Леонид хэлэв.

Глеб замын турш ярьж, Саша сонсож явав.

-Калинин чиний сэтгэлд таарна, ялдам минь, чи Волга дээр очиж байсан уу?

-Ерөөсөө үгүй.

-Надад нэг танил загасчин бий, зун тэднийд хонуудаар очимц, тэгээд нар битүү босч, мөрний

дээгүүр суусан битүү мананг харна, тийм юм харсны дараа үхэхэд ч гомдолгүй гэж мэд.

-Үхэх арай эртдэх юм биш үү? хэмээн Саша инээвхийлэв.

-Тийм шүү, хүлээзнэнэ ээ. Чи хаана аж төрж байна вэ?

-Одоохондоо хаа ч үгүй, өрөө хөлслөх хэрэгтэй байна.

-Олно доо.

-Хөлслөх хүн чи мэдэхгүй биз?

-Бүү мэд, ер сонирхож явсангүй, гэхдээ сураглая.

-Хүүе, тэгж үзээрэй.

-Заавал сураглана, ялдам минь, заавал гээд Глеб Леонид ирж яваа эсэхийг эргэж харав. -Аль вэ, хө, зам гарч дэлгүүрт очъё. Кафед архи байхгүй, ганцхан улаан дарс л байдаг юм. Өөрснөө авч очих хэрэгтэй. Людка бидэнд улаан ус ч юм уу, нэг юм ширээн дээр тавина биз, тэгэхгүй бол болохгүй. хүнсний дэлгүүр энэ байна.

-Хэдийг авахав?

-Дөрвөн эр хүн байна, тэгэхээр хоёр шилээр суухад болно.

-Дөрөвдэх нь хэн юм бэ?

-Чиний механик Хомутов, тэр чинь, ялдам минь, чиний хувьд хамгийн гол хүн. Манай энд чинь хамгийн түрүүнд лонх юм л тавих ёстой!

Саша дэлгүүрт орж, хоёр шил юм пальтоныхоо халаасанд хийчихээд буцаж ирэв.

-Аль вэ, өгөөтөх!

Глеб архийг цүнхэндээ хийв.

Леонид ирлээ.

-Юмаа цэгцэлчихэв үү?

-Номын ёсоор гэж Глеб хариулаад, -Механик хаачив? гэж асуув.

-Салгалаад ирж л таарна.

Тэд нар кафед орж хувцсаа тайлцгаав. Өлгүүрийн архичин царайтай, гар нь салгалсан, үлхгэр өвгөн тэднийг таних боловч, зөвхөн Леонидэд анхаарал тавин, пальтог нь пайзгүй өлгөөд, Саша, Глеб хоёрт дор бүрд нь пайз өгөв.

Глеб Людаг олохоор танхим руу ороод, буцаж ирэв.

-Явцгаая!

Люда нэг буланд тэдэнд зориулан ширээ засч байснаа Саша руу, юу болсныг мэднэ, баяр хүргэе гэсэн шиг инээмсэглээд, тонгойсхийн,

-Надад бас чамд дуулгах сайхан мэдээ байгаа, дараа хэлье гэв.

Тэгээд цэхрэн зогсож, харандаа дэвтрээ зэхлээ.

Глеб хоолны цэсийг харах зуур,

-Эхлээд, юу ч гэсэн, рашаан, том хундагануудтай аваад ир, бид юу авахаа бодож байя. За, эрхмүүд минь, май загас авна л биз дээ? Нялхаар нь дарсан хэмх, зүйтэй юү? Давтсан мах... Энэ махыг ч бид мэднэ дээ. Шницель? Энэ зүйтэй байх. Саша, май, чи эзэн хүн, өөрөө хар гэв.

Саша ганц хуудсан дээр машиндсан хоолны цэсийг авлаа.

-Нэмж хиам авах юм уу?

-Хиам бас болно шүү.

Люда хундага, таваг, хутга, сэрээ, хоёр шил рашаан авчирч өгөөд,

-Та нар болгоомжтой яагаарай гэж анхааруулав.

Саша төмстэй май загас, чанамал хиам, шницель захив.

-Чи эд нарыг дайлж байгаа юм уу?

-Өөр хэн байхав, ажилд орчихсон, одоо сууц хайж байгаа хүн гэж Глеб өмнөөс нь хариулав.

-Сууц ч бас олдоно гээд Люда жогтой инээмсэглэв.

-Тэгвэл байраа хамтад нь тэмдэглэчихье, хүүе, Людмилочка, үгүйдээн, загасаа бушуухан аваад ир, би сэтгэл хөөрөөд байна шүү гэж Глеб үглэв.

-Өө, Хомут хүрээд ирлээ гэж Леонид өгүүлэв.

Механик Хомутов ирж сул сандал дээр суугаад, Леонидтэй машин тэрэгнийхээ тухай яриад эхлэв.

-Энэ хоёрыг салгаж суулгахгүй бол одоо үйлдвэрлэлийн зөвлөлгөөн болгочихно гэж Глеб өгүүлэв.

Леонид, Хомутов хоёр түүний хэлснийг юман чинээ тоосонгүй.

Глеб Саша руу нүд ирмээд, дөхөсхийн суув.

-Орос хүн наргиж чадах биш дээ. Өдөржин ажил дээрээ элдэв асуудал шийдэж, ярьж ярьчихаад, орой ганц хундага юмны ард уулзахаараа дахиад л нөгөө ажлынхаа тухай бурж гарна. Чихэнд чийртэй гэж. Энэ Хомутов байна шүү, саяхан хүүтэй болсон юм, авгай нь арван жил хүүхэд гаргахгүй явснаа гэнэтхэн хөл хүндэрч. мань эр баярласандаа болоод долоо хоног нэвширтэл уусан. Тийм хүн чинь баньдтайгаа яаж аан уун болж байна, цаадах нь яаж мөөмөө хөхөж байна, одоо охинтой болохын тулд авгайгаа яаж цондойлгож байгаа энэ тэрээ ярьдаг байгаа даа. Ардууд аа, яриагаа орхи, рашааны өмнө нэг ууцгаая! хэмээн Глеб сэрээгээр тавгаа тогшлов.

Ууцгаалаа.

Глеб Саша руу дахиад дөхөсхийв.

-За, хоюулаа нэг шилээр, чамайг хүсвэл хоёр, гурваар ч хамаагүй мөрийцье, ялдам минь. Би одоо энэ хоёр юу ярихыг нэгд нэгэнгүй чамд урьдчилаад хэлчихье, нэгд, Прошкиныг зүхнэ, хоёрт, Прошкиныг зүхнэ, гуравт, Прошкиныг зүхнэ, манай баазын даргыг тэр шүү дээ, чи түүний хоншоорыг хараагүй биз дээ? Харна аа, гайгүй. Леонид түүнтэй муур, нохой хоёр шиг шөргөөлцдөг юм. Прошкин “а” ч үгүй амьтан, талхны заводын дарга байсан юм, шөнө нь хайрсан хуушуураа хулгайд алдчихаад, өглөө гэхэд хоосон тэвштэй сууцгааж байдаг гэнэ лээ. түүнийг халаад автобааз руу шилжүүлчихсэн, машиныг хулгай хийнэ гэж байхгүй, том юм чинь, хуушуур бол хоёр хазаад л алга болно шүү дээ. Леня, миний ярьж байгаа зөв үү?

Леонид хариуд нь амандаа нэг юм бувгнав.

-Леня инженер, намын гишүүн, ажил явдлаа мэдэх хүн юм чинь дүлий годил шиг юмаар удирдуулахад, мэдээж, гомдолтой байлгүй яахав. Би нэг удаа өрөөнд нь санаандгүй орсон чинь, мань эр сар руу хуцаж байгаа нохой шиг толгойгоо өлийчихөөд ульж байна. Нээрэн шүү! Прошкин энүүнийг бүр ийм болгочихоод байгаа юм.

Саша инээв: “Тэвчээр барагдвал улих ч энүүхэнд”.

Люда төмстэй май загас авчирч өгөөд, зүссэн хиамтай тавгаа ширээн дээр тавилаа.

-Халуун хоолоо авах болохоор хэлээрэй гэснээ Люда Саша руу тонгойсхийн, -Сашок, энүүхэнд өрөө олсон, манай өлгүүрийн өвгөний өрөө гэж хэлэв.

-Егорычийн тэр ч сайхан шүү гэж Леонид өгүүлэв.

-Газар давхар, гэхдээ чийггүй. Дамждаг өрөө, эзэд нь наана нь сууна, эзэд гэдэг нь Егорыч, тэдний эмгэн хоёр. Сард гуч, хоёр долоо хоногоор урьдчилж төлнө, юм угаалгавал, мэдээж, жич тооцно. Буцалсан усыг тэднийх гаргана. Хоол энэ тэр гэвэл эмгэн хийгээд өгнө.

-Сайхан байр, айл нь ч сайн айл гэж Леонид дахин өгүүлэв. -Үнэнийг хэлбэл, хоюулаа ууна, тэр яахав, одоо уухгүй хүн гэж байх биш. Уулаа гээд агсрах элдэвлэх юм байхгүй, номхон,

томоотой хөгшчүүл.

-Сашок, яахав, ийм байдлаар тохиролцох уу? Удаан бодвол тэр байр алга болчихоно шүү.

-Надад бодоод байх юм алга. Би бэлэн байна.

-Цагаан хэрэглэлээ угаалгаж байхаар тохир, хоол хийлгэх хэрэггүй, гуанзаар болгож бай гэж Леонид зөвлөв.

Люда Сашагийн мөр рүү эелдэгхэн илбээд,

-Тайван сууцгаа гэв.

Механик хүүхний гар руу тогтож харснаа толгой сэгсрэв.

Тэгснээ Саша руу харж, түүнийг бас ярианд оролцуулах санаатай гомдоллож гарав:

-Намайг ч санааныхаа зоргоор эргүүлцгээх юм даа. Жолооч нар ямар замын хуудсанд гарын үсэг зуруулдаг гэж санана. Онгоцоор нисээд барахааргүй километрийн тоо тавьчихна. Би шал худлаа гэж мэдсээр байгаа хэрнээ, Прошкиныг дээшээ илтгэх юмтай болгох гээд гарын үсэг зурчихна. Мэдчихвэл хэнтэй хариуцлага тооцохов? Яах гэж гарын үсэг зурсан бэ? гээд надтай л тооцно шүү дээ.

-За дахиад дуртай морио унаад хадуураад давхичихлаа. Нээрэн, орос хүн даанч наргиж чадахгүй юм. Яагаад ингэдэг юм бол, ялдам минь гээд Глеб санаа алдав.

Яагаад гэдэг нь тодорхой байна. Хадны завсраар хавчуулсан мэт нөхцөл байдал, ажил явдалдаа багалзуурдуулсан хүн яаж наргих сан билээ дээ. Саша энэ сэдвээр Всеволод Сергеевичтэй бол ярилцах л байсан, Глебтэй бол амаа хамхиж байсан нь өлзийтэй. Шалихгүй юм шиг энэ асуултыг санамсаргүй тавиагүй биз, илэн далангүй ярилцах санаатай ч байж мэднэ.

-Мэдэхгүй, энэ тухай бодож яваагүй юм байна хэмээн Саша инээмсэглэв.

Люда ирж Сашаг дуудав. Тэр хоёр өлгүүрийн өрөө рүү гарлаа.

Өлгүүрийн өвгөн Сашад гараа өгч,

-Алексей Егорович гэж өөрийгөө танилцуулав.

-Люда болзлын тухай надад хэлсэн, энэ арван таван рубль, май хэмээн Саша өвгөнд мөнгөө өгөөд, -Өнөөдөр нүүж орж болох уу гэж асуув.

Егорыч мөнгөө далд хийнгээ,

-Цэвэрлэвэл зүгээрсэн гэв.

-Энүүнийг галт тэрэгний буудал очиж чөмоданаа авах хооронд эмээ өрөөгөө цэвэрлэчихнэ биз гэж Люда хэлэв.

Саша ширээ рүүгээ буцаж ирэв.

-Нядалчихсан шүү гээд Глеб цүнхээ онгойлгон хоёр хоосон шилээ харуулаад, -Цаг ч байна, дэлгүүр ч онгорхой байгаа, жаахан нэмэх үү, ялдам минь? гэв.

-Дэлгүүр онгорхой ч, манайх одоо хааж байна, хоёр шилний

бодь хөтлөсөн, одоо болоо биш үү гээд Люда тооцоогоо ширээн дээр тавилаа.

Саша мөнгөө төлөв.

Цөмөөрөө босцгоов.

-Леонид Сашаг байранд нь хүргээд өг гэж Люда хэлэв.

Тэр дөрөв кафенаас гарцгаав. Хомутов гэр рүүгээ явж, Леонид, Глеб хоёр Сашаг орох байранд нь хүргэж ирэв. Газар давхар руу тавхан гишгүүр алхаж бууцгаалаа. Гэрэл бүдэгхэн учир хаалга нээж өгсөн эмгэний царайг Саша сайн харж чадсангүй.

-Матвеевна, зочноо хүлээж аваарай гэж Леонид хэлэв.

-А-аан, Леонид Петрович, орцгоо.

Сарампай хавтангаар дундуур нь хана хийсэн овоо том өрөөнд орж ирцгээв. Хаалганы оронд нэг муу даавуун хөшиг унжуулжээ. Утаанд идэгдсэн бохир адартай, хариугүй нурж унах нь гэмээр тавилгатай, өрөөний наад хэсэгт цахилгаан тулгатай, гал тогооны үнэр нэвчсэн, хог новш хөглөрсөн, сэтгэл татах юмгүй байр аж. Гэхдээ л оромж.

-Ө-өө, аргагүй “люкс” буудал байна... гэж Глеб нохойтов.

Гэрийн эзэгтэй мухрын өрөөний ванданг үзүүлж,

-Унтах ор чинь энэ, хажууд нь ширээ байна, хэрэгтэй бол саравчнаас мухар сандал авчирч өгөмц гэснээ хэсэг новширсон юм руу зааж, -Би үүнийг хумиад авчихна. Шалаа шүүрдчихнэ тэгээд бүх юм цэвэрхэн болно гэв.

-За, яахав, би одоо явж чөмоданаа авчирна, та тэр хооронд өрөөгөө янзалчих гэж Саша хэлэв.

-Урьдчилгаа өгвөл зүгээрсэн гэж эмгэн Саша руу харалгүй амандаа бувтнав.

-Урьдчилгаагаа би Алексей Егоровичид өгчихсөн.

Эмгэн янзгүй царайлж,

-Яах гэж тэрүүнд өгсөн юм? Гударчихна. Хоолны газар байдаг хүн мөнгөөр яахав? Леонид Петрович шиг надад л өгч байгаарай гэв.

-Тэгье ээ, цаашдаа танд л өгч байя.

Гадагшаа гарцгаав. Саша нөгөө хоёртойгоо салах ёсыг ёслоод, галт тэрэгний буудал орж, чемоданаа аваад эргэж ирэв.

Егорыч гэртээ ирчихэж.

Саша өөрийнхөө байх хэсэг рүү орох зуур,

-Сайхан нойрсоорой гэв.

-Тавгай нойрсоорой гэж хоёр хөгшин хариулав.

Вандан дээр дэр, нэг ширүүн цэрэг бүтээлэг хоёр байна. Дэрний уут, цагаан давууны аль нь ч алга, өөрөө худалдаж авах хэрэгтэй болох нь.

Саша хувцсаа тайлж, гэрлээ унтраагаад, нөгөө бүтээлгийг нөмрөн хэвтэв. Бүтээлэг эхлээд энд тэндгүй хатгаж байвч, мань хүн тэр дороо нойронд автжээ.

Ээж нь бүтэн сайнд утасдана гэж хүлээж байгаа учраас наана нь Варятай ярих ёстой. Утасных нь дугаараар захиалга өгөв.

-Байна уу...

Дууг нь шууд танилаа.

-Варенька сайн байна уу, би Саша байна, сайн дуулдаж байна уу?

-Тэгж байна, маш сайн дуулдаж байна. Чамаар юу байна? гэж Варя холбоо тасарчих вий гэсэн шиг бачимдан өгүүлэв.

түүний дуу зүрхийг зурах мэт болов.

-Миний бүх ажил бүтэмжтэй, автобаазад жолооч хийж байна.

-Чамайг Москвад байхад чинь уулзаж чадаагүй нь их тоогүй юм болсон.

-Харин тийм ээ. Гэхдээ чи мэдэх байх, би Москва хоттой ямар харьцаатай болсныг ээж чамд ярьсан байлгүй.

-Тийм ээ, бүгдийг нь мэдэж байгаа. Гэхдээ Калинин хүрэхэд ойрхон юм чинь би чам дээр очсон ч болох байна.

Саша ийм юм сонсоно чинээ санаагүй учир юу гэж хариулах ухаанаа олохгүй сандрав. Гэвч

заавал хариулах хэрэгтэй.

-Юу л даа... Би одоо хэр орон байргүй байгаа.

-Үгүй ядахдаа, галт тэрэгний буудал дээр жаахан сууцгаахгүй юү. Өглөө Москвагаас наад руу чинь галт тэрэг явдаг, Калининаас орой наашаа гардаг юм байна лээ.

-Тэр бүтэхгүй ээ, би өдөр нь ажилтай, заримдаа алсын тээвэрт гарах нь ч бий, ингэхэд, Москва руу бас явуулдаг юм, би ээжид урьдчилаад хэлчихнэ, чи ажлынхаа утсыг ээжид өгчихөөрэй, тэгээд хоюулаа уулзъя.

Варя чимээгүй болчихов.

-Байна уу, байна уу! Варя чи, хаашаа ч юм бэ, алга болчихлоо.

Варягийн дуу сонсдохтой үгүйтэй болчихсоныг Саша утас муу байгаагаас болж байна гэж бодов.

Тэгж тэгж,

-Байна гэж Варя дуугарав.

-Одоо зүгээр байна. Москвад очингуутаа би утасдана, тэгээд уулзъя. За юу? Миний ачаа авах газар руу ээж та хоёр яваад очно биз.

Холбоочин хүүхний дуу харилцуурт орж ирэв:

-Таны цаг дуусч байна.

-Байзаарай, байзаарай! Варя, чи цөмийг нь ойлгосон биз?

-Надад өөр хэлмээр юм алга уу, Саша? гэж Варя урамгүй дуугаар асуулаа.

Тэрээр хариу хэлж амжсангүй.

-Таны цаг дууссан хэмээн холбоочин хүүхний дуу харилцуурт дахин хадав.

Саша түүний асуултад хариулсангүй, хэлэх үг ч байсангүй, тэр бүү хэл, уулзахаас ч дөллөө. Костягийн явдлыг уучилж чадахгүй байгаа нь тэр. Тэр тухай юу ч мэдэхгүй явж байгаад гэнэт тархиараа татуулах мэт тийм юм сонссон. Костягийн тухай бичээгүй нь үнэн, гэхдээ ер нь юу бичсэн билээ? Онцгой юм байхгүй. Саша ч гэсэн өөрт нь онцлох юм бичээгүй. Бүх санаагаа гагцхүү бичигдсэн зүйлийн цаанаас олж харж, зөвхөн хоюулхнаа ойлгодог байсан юм чинь. Саша өөрт нь хайртай байсан, өөрөө үүнийг мэдэрдэг байсан, тэр бол хүүхний өөрийгөө хуурсан сэтгэл биш. “Арбатын нүх”-энд шинэ жил тэмдэглэхэд яаж өөр рүү нь харж байлаа, тийм харц мартагдана гэж байхгүй, бас шоронгийн гаднах оочер ч мартагдана гэж байхгүй.

Варя бүр цөхөрч гүйцэв. Софья Александровна яах гэж тэр Костягийн тухай түүнд ярив аа? Өөрийнх нь Сашад хайртай гэдгийг даанч ойлгохгүй байлаа гэж үү? Одоо ингээд бүх юм нурчихлаа. Юунаас болж гээч? Костягаас... ээ, бурхан минь! Ийм дэмий юмнаас! Сашаг харгалзагч нарт туугдаад өөрийн эрхгүй, дуулгавартай, өрөвдөлтэй амьтан явж байхыг хараад, бүх юм балар харанхуй, мухар сохор мэт санагдаж, тэр харанхуйгаас гарах гарц хайж, биеэ даасан хүн болохыг зорьж, чухамдаа томоогүй охин явахдаа Костя тэр бүхнийг нь өгөх юм шиг түүнийг дагаж харайлгасан, тэнэг тол-гой. Уул нь энэ бол орчин тойронд болж байсан хачин явдлын эсрэг, Сашад тохиосон хачин явдлын эсрэг тэмцсэн түүний эсэргүүцэл байсан билээ.

Костягийн бие даасан байдал гэгч домог болохыг дараа нь ойлгосон, Костя мөрийчин төдийгүй хүний адаг болохыг мэдсэн. Левочка, Рина хоёр ч Костягаас хишиг горьдсон сэжигтэй этгээдүүд. Игорь Владимирович бол тэдэнтэй жишихийн аргагүй чадвартай, журамтай хүн, гэтэл түүнийг үйлдвэрчний гишүүнд элсэх хурал дээр ямар арчаагүй царайлж байлаа даа, номхон хонь л гэсэн үг, нөгөө мундаг инженер, техникчид нь ч гэсэн яг л хонь шиг байцгаасан. Ганц Саша л жинхэнэ хүн, Тэрээр зөвхөн түүнийг л хүндэлж, хайрладаг.

Гэтэл ингээд бүх юм нурчихлаа. Тэрээр Сашаг утсаар ярихаас өмнө эрхибиш горьдлого өвөрлөж, Калининд очиж, үгүйдээн, буудал дээр ч гэсэн ярилцана, хайр сэтгэлтэйгээ түүнд хэлнэ, Костягийн тухай үнэнийг илэн далангүй ярина гэж бодож явсан билээ. Тэгсэн бол Саша ойлгож уучлана. Гэтэл тэр уулзахаас дөллөө, дотроо бүх юмаа шийдчихсэн юм байна, өөрийг нь хэрэгсэхгүй орхиж. Б ү х ю м дуусчээ. Ингээд дуусч. Бурхан тэнгэр минь! Одоо яаж аж төрөхөв? хэний төлөө гэж аж төрөхөв?

Тэрээр ажил, сургуульдаа үүлгэртэн явж, нэг мэдэхэд метронд орчихсон, нэг мэдэхэд гэртээ ирчихсэн, заримдаа пальтогоо ч тайлаагүй, аав ээжийнхээ зургийг хараад сууж байх болжээ. Тэр хоёрынхоо тухай мэдэх юм тун маруухан, аав нь гучин хоёртойдоо уушгины сүрьеэгээр өөд болж, ээж нь ер өвчин хууч гэдэггүй хэрнээ хойтон нь нас баржээ. Козлов хотноо аж төрдөг ээжийнх нь дүү тэгэхэд, “Ээж нь гунигт автан, хайлж элэгдэж байхыг үзээд аав нь өрөвдөж, өөр рүүгээ аваачсан юм” гэж ярьсан билээ. Варя тэгэхэд бүр жаахан байсан болохоор учир мэдэхгүй, “Хааш нь аваачсан юм бэ?” гэж шалгаана. Нагац эгч нь “Тийш нь” хэмээн тэнгэр өөд харна. Тэгэхээр Варяд бас тэнгэр өөд гармаар санагдана. “Аав биднийг яагаад авахгүй байна?” - “Та нарт энд сайхан байна, та нар энд мөн ч удаан аж төрнө, энд муу байгаа улсыг тийш нь аваачдаг юм”. Варя өөрөө бас ээж шигээ одоо гунигт автан хайлж

ЭЛЭГДЭХ НЬ.

Софья Александровна утасдлаа.

-Варюша, чи хааччихав аа, би санаа зовоод л байна.

-Софья Александровна, би яаралтай ажилтай болчихоод гэртээ авчирч хийж байгаа юм, хэд хоногоос дуусна, тэгээд танайхаар орно оо гэж Варя аргалав.

-Саша чамд утасдсан уу?

-Тэгсэн, утасдсан, бүх юм ёсоор болсон.

-За, яамай даа, би чамд эс хэл лүү хэмээн Софья Александровна баярлацихав. -Бушуухан ирээрэй, хоюулаа юмаа ярилцъя.

Гэвч ярилцах юм байхгүй: Саша түүнд дахиад утасдахгүй. Калининаас ч утасдахгүй, Москвагаас ч утасдахгүй. түүний дууны өнгөнөөс баярласан, сэтгэл хөдлөсөн, догдолсон аяс өчүүхэн ч мэдэгдээгүй. Нөхөрсөг, уриалгахан дүр зохиомлоор эсгэсэн. Ёс төдий утасдсан. Софья Александровна л гэмээ булах гэж ятгаж утасдуулсан хэрэг.

Гэтэл Саша Костягийн тухай мэдээг тэгж эмзэг хүлээж авч байгаа нь хайр сэтгэлтэйн илрэл гэх нэгэн дуу хоолой алсын алсаас сонсдоод байх шиг. Хэрвээ хайр сэтгэлтэй бол бүх юм баларсан гэж үзэж болохгүй. Уулзаж л ярилцах юм сан! Харин яаж уулзах вэ?

түүний дотуураа шаналж явааг зөвхөн Игорь Владимирович анзаарч, нэг хэсэг бэргэж явсны эцэст,

-Варенька, та их ядруу царайтай байх чинь. Гомдох, гутрах юм гараа юу? Долоо хоногийн амралт авах юм биш үү? гэж шууд асуужээ.

-Долоо хоногийн амралт ий? хэмээн Варя олзуурхав. Хэрэгтэй юм чинь яг энэ. Калинин руу, Саша дээр оччихоод ирдэг хэрэг. Гэтэл тэнд очоод яаж түүнийг олохов? Софья Александровнад ч хаягаа өгөөгүй, холбоо руу өөрөө хүлээн авагч гэж захиа бичиж байгаарай гэсэн байсан. Варя урам хугарч, -Үгүй ээ, Игорь Владимирович, хэрэггүй, баярлалаа. Зүгээр л, миний толгой жаахан өвдөөд байгаа юм. Яльгүй салхи авчихсан байх гэв.

-Манай Варвара эсвэл ханиад авч, эсвэл жаахан ядарч, эсвэл жаахан гутарч хэмээн Левочка ярианд оролцов. Тэрээр бэлэн цэцэн үгтэйг ч хэлэх үү, сүүлийн хэд хоног ам хамхихгүй хөөрч байгаа ажээ. Учир юун гэвэл, Игорь Владимирович хөөцөлдөж байж, Варя тэр хоёрыг ахлах техникч-зохион бүтээгчид болгосон юм байж. Харин Рина нөгөө л техникч-зурагчнаараа үлджээ.

-Бүтэн сайны орой “Метрополь”-д орж, мартсанаа сэргээвэл ямар вэ? гэж Левочка санал гаргав.

Варя хоёр жил ресторанд ороогүй ажээ.

-“Метрополь” ий? Тэр чинь хаагдаагүй юм уу? гэж Тэрээр гайхаж асуув.

-Баар, хөнгөн хөгжим, дуу, бүжиг, тоглоом гээд бүгд хуучнаараа байгаа. Яагаад орж болохгүй байхав? гээд Левочка малилзан инээмсэглэв.

-Тэгвэл яасан гэж баяр болох гэж байна?

-Мирон урьж байгаа юм. Чи түүнийг санаж байна уу? Буржгар үстэй, нэг хээгүй залуу.

-Костягийн найз уу?

-Биднээс ялгаа юу байхав.

-Тэр чинь гэнэт яачихаав?

-мань хүн гуч хүрч байгаа, тэгээд хуучин найз нартайгаа төрсөн өдрөө тэмдэглэе гэсэн юм.

-Та хоёр харилцаатай байдаг юм уу?

-Тэгэлгүй яахав, бид найз нар.

-Өөр хэн очихов?

-Өөр... Би, чи, Рина... Ика, аль хэзээ, бүр хоёр жилийн өмнө хилийн чанад руу яваад өгсөн гэснээ Тэрээр дуугаа намсган, -Чи сониноос уншсан байлгүй, нөгөө Коминтернд ажиллаж байсан эцэг Вилли Лонга нь германы тагнуул болж таарсан, тэгээд тэднийг ам бүлээр нь гадаадад хөөж явуулсан гэнэ лээ гэж шивнэв.

-Чи юу гэж шивнээд байна аа? Сонинд гарсан гэж чи сая хэлээ биз дээ? хэмээн Варя жуумалзав.

-Тийм л дээ, гэхдээ түүнтэй нөхөрлөж байснаа бид дурдаад байх шаардлагагүй.

-Тэгвэл нөгөө том Воля, жижиг Воля хоёр?

-Үзэгдэхээ больчихож. Би ойрд тэднийг хараагүй.

-Би тэнд чинь Костятай мөргөлдчихгүй биз?

-Костятай? Чи мэдээгүй гэж үү?

-Юуг?

-Тэр чинь Таганкийн шоронд байгаа.

Тийм байж. Тэгэх л гээд байсан хүн л дээ.

-Яасан гэж тэр вэ?

-Варя, чи түүний ажил явдлыг мэднэ шүү дээ.

-Би түүний ямар ч ажил явдлыг хуучин ч мэдэхгүй, одоо ч мэдэхгүй, мэдэхийг ч хүсэхгүй байна.

-Тийм ээ тийм. Би ч бас мэдэхгүй. Нөгөө л наймаа арилжаа, чийдэн, патент, татвар энэ тэрээсээ болоо биз, бас билльярд ч хамаатай л биз.

-Тэгж яривал, түүний тэр “наймаа арилжаагаар” Рина та хоёр багагүй идэж ууж наргицгаасан, анд нөхрийнхөө хувь заяаг сонирхож болмоор юм даа.

-түүнийг сайн өмгөөлөгч өмгөөлөх гэж байгаа, гэхдээ их мөнгө шаардсан, тийм мөнгө надад яаж байхав, Костя хожим тооцоо хийнэ гэж амлаж байгаа ч тэр бол ам төдий зүйл.

-түүнийгээ эргэж очдог уу?

-Хэдийд нь эргэх вэ дээ? Бүтэн өдөр оочерт зогсох хэрэгтэй, гэтэл Рина бид хоёр ажилтай улс.

-Та нар чинь найзууд шүү дээ, зовлонд унасан нөхрөө яагаад хаяж байна?

-Бид яаж ч чадахгүй, ёстой мөхөсдөнө, чи үүнийг сайн ойлгож байгаа, ер нь юу гээд бухимдаад байна? Костя яаж ийж байгаад мултрана гэж би бодож байна.

Костягийн хувь заяа Варяд падгүй л дээ. Шоронд орж таарна гэдэгт Тэрээр эргэлзэж байгаагүй. Гэхдээ анд нөхрөө зовох цагт нь орхих ёсгүй. Ичмээр юм. Үүнийг хэлэх гэсэн хэрэг. Тэгээд ч хэлсэн нь тэр.

-Чи ирэх юм уу, үгүй юү? гэж Левочка асуув. -Мирон чамайг ирээрэй л гээд байна лээ. Чи нөгөө найз Зоягоо яахсан бэ, өөрөө мэднэ биз.

-Би ганцаараа очно гэж Варя хэлэв.

-Бид яг долоон цагт Их театрын урдах цэцэрлэгт цуглаад бөөндөө явцгаана. Мирон ширээ захьчихсан байгаа.

“Метрополь” хуучин юмгүй болжээ. Уул нь гэрлийн болор цацаг, ширээн дээрх цардмал алчуур энэ тэр яг хэвээрээ байна. Хөгжим тоглож эхлэнгүүт гэрэл бүдгэрч байна. Танхимын зохион байгуулагч хуучин янзаараа зочдоо угтаж, уриалгахан үйлчлэгч тэднийг тосч аваад ширээ ширээнд нь суулгаж байна. Гэвч үйлчлүүлэгчид нь тэс өөр болжээ. Албаны хувцастай дарга нар олширч. Тэртээ буланд хоёр, гурван ширээ нийлүүлчихээд кавказынхан бололтой хүмүүс найрлацгааж байна. Гадаадынхан бараг алга, байгаа нь яриа хэлэлцээнийхээ дараа албаны хүмүүстэй хамт түргэхэн юм амхарахаар ирсэн бололтой. Баян тансаг өмсгөл, гоёлтой авхай нар алга, Вика, Ноэми, Шеремьетева эд нар шиг ганган хүүхнүүд алга. Харин зөвлөлтийн ердийн албан хаагчдын хувцастай янхан хүүхнүүд дарс шимцгээж сууна.

Нөгөө хэдийн захиалсан ширээн дээр цагаан архи, дарс хэдийн тавьжээ. Мирон загасны

цуглуулган зууш, хямдагтар халуун хоол, мөхөөлдөс захиалав. Энэ бол хуучин заншил. Бүжиглэх гэж ирсэн залуус бага юм захиж, харин зөөгч нарт гайгүй юм атгуулна. Левочка, Рина хоёр ч эндээс салдаггүй хэвээрээ аж. Мирон бол бүр мэдээж, яг л хуучин шигээ тогтож сууж чадахгүй, нэг тийш явж, нөгөө зүгээс ирж, үл ойлгогдох юм ярина.

Дөрвүүлээ жигдрээд суумагц, Костягийн тухай ярих гэж ийнхүү цугласан нь Варяд илэрхий болов. Эд нар бүгдээрээ Костягийн найз, Мироныг бол хамтран зүтгэгч ч гэж хэлж болно.

-За, тэгэхээр, ууцгаах уу? гэж Мирон хэлэв.

Ууцгаалаа. Тэгмэгц хоёр жилийн өмнөх шиг утга зорилгогүй хоосон яриа эхлэв. Шар үстэй, сэвхэн нүүртэй Рина доржноо сэргэн царай орж, нүд нь гялалзаад ирлээ. Зураг төслийн газар ажиллах гэж төрсөн хүн үнэхээр биш. Левочка ч усандаа орсон загас л гэсэн үг. Харваас атаархмаар идэж, ууж байна, хөгжим дуугарангуут тийнхүү баясан бүжиглэхээр босно, амьдралын амтыг аргагүй хүртэж чаддаг хүн. Ингэхээр, аз жаргалтай амь зуухад хүнд, чухамдаа тун яльгүй зүйл хэрэгтэй юм санж дээ, өөрөө эд нар шиг яагаад аз жаргалтай байж чаддаггүй билээ? гэсэн бодол Варяд төрөв.

Мирон Варя руу олон жилийн найз шиг нүүр өгөх гэж мэрийх аж. Өнгөрсөн бүхий л хугацаанд хоёр үг ч түүнтэй солиогүйгээ Варя саналгүй яахав. Одоо ч тэдэнд ярих юм алга. Гэхдээ чухамхүү Мирон л түүнтэй нэг юм ярилцах гээд байгаа нь гарцаагүй боллоо.

Хөгжим эгшиглэж, Левочка, Рина хоёр бүжиглэхээр явцгаав.

-За, Варя ажил хэрэг ямар шүү байна? гэж Мирон хээгүй инээмсэглэн асуув.

-Ажил хэрэг үү? Хуучныг бол архивт өгчихсэн.

Варя түүн рүү яавал ч яаг гэсэн царайтай харлаа.

Цаадах нь, яагаад ч юм, хамраа маажсанаа, хоёр хундагыг зөрүүлж тавив.

-Хүүе, Варя, Костяд яаж ийгээд тусламаар байна.

-Тодорхой хэлбэл?

-Өмгөөлөгч хэрэгтэй байна.

Варя түүнийг хүлээнэсхийн харж, хариу хэлсэнгүй.

-Чи намайг ойлгов уу? Өмгөөлөгч хэрэгтэй байна.

-Тэгээд юу гэж?

-Өмгөөлөгч авахад мөнгө хэрэгтэй.

-Хэдэн рублийн чек бичиж өг гэж тушаах гэж байна хэмээн Варя доогтой хямсайв.

-Чи Костяг даан ч өрөвдөхгүй байна гэж үү?

-Даан ч үгүй. Тэр яахав, чи надаар яалгах гээв? Хэлээч!

-Варя, өмгөөлөгч хэрэгтэй, мөнгө хэрэгтэй гэж би чамд хэллээ шүү дээ.

-Би өмгөөлөгч олох ёстой юм уу, мөнгө өгөх ёстой юм уу?

-Өмгөөлөгч надад байна, харин мөнгө хэрэгтэй.

-Надад мөнгө байхгүйг чи сайн мэднэ шүү дээ.

-Чамд мөнгө болгочихоор эд юмс бий.

-хэн чамд тэгж хэлээв?

-Костя.

-Тэр юу гэж хэлж байна?

-Би түүнтэй уулзаагүй, харин гадагш нь зурвас гаргасан нь энэ байна гээд түрийвчнээсээ сонины тасархай дээр Костягийн “Варя, миний бүх юмыг өмгөөлөгч авахад зориулж зар. К.” гэж бичсэн зурвас гаргаж өгөв.

Варя тэр зурвасыг дэргэдээ тавилаа.

Мирон гараа сунган,

-Өгөөтөх гэв.

-Яах нь вэ? Энэ чинь надад бичсэн зурвас шүү дээ.

Тэрээр зурвасыг тавган доогуураа хийгээд бодолхийлэв.

Хөгжим зогсож, Левочка, Рина хоёр буцаж ирэв.

-Аль вэ, Мироны төлөө ууцгаая гэж Левочка хэлээд, -Мирон, чи үнэхээр гучтай гэж үү дээ? гэж асуув.

-Тэгээд л бодчих, өвгөн минь. Чи ч бас тойрохгүй дээ.

Левочка хундагаа өргөв:

-Чиний төлөө, Мирон.

-Байзнаарай! Байзнаарай! гээд Варя хундагаа ширээн дээр тавив. -Мирон надад Костягийн зурвасыг дамжууллаа. Энэ байна, би уншъя: “Варя, миний бүх юмыг өмгөөлөгч авахад зориулж зар”. Би үүнийг юу гэж ойлгох вэ?

хэн ч дуугарсангүй.

Тэгтэл Рина толгой сэгсрэн,

-Би энэ тухай юу ч мэдэхгүй гэв.

-Би ч бас мэдэхгүй гэж Левочка яаран өгүүлэв.

-А-хаан, мэдэхгүй гэнэ ээ, намайг яах гэж ийш нь ирүүлснээ мэдэхгүй байх нь. Мироны төрсөн өдрийг тэмдэглэх гэж гэл үү. Сайн байна. Тэгвэл Мирон энэ зурвасыг надад өгсөн гэдгийг та хоёр гэрчлэнэ шүү.

-Чамд үүнийг хэн өгснийг би хараагүй шүү гэж Рина дал мөрөө хавчив.

-Тийм шүү дээ, Варя, Рина бид хоёр бүжиглэж явсан юм чинь, та хоёрын энд юу ярьсныг мэдэхгүй гэж Левочка нялуурав.

Варя Мирон руу харж,

-Чи энэ зурвасыг надад өгснөө хүлээж байгаа биз? гэж асуув.

Мирон хэсэг дуугүй байснаа,

-Үгүй шүү, би чамд юу ч дамжуулаагүй гэв.

-Өө, тийм үү гээд Варя зурвасыг цүнхэндээ хийв. -Тэгвэл боллоо, асуулт алга. Одоо ууж болно шүү.

Мирон хундаганаасаа нэг балгаснаа буцааж тавиад, хуруугаараа ширээ тогшлон Варя руу эгцэлж харав:

-Костяг аврах хэрэгтэй байна, чи мэдэж байна уу,

-Аварцгаа л даа.

-За, чи битгий цаагуур орох гээд бай! хэмээн Мирон гэнэтхэн ширүүлж эхлэв. -Энэ зурвасаар манийг сүрдүүлэх гэж бодоо юу, тэр бүтэхгүй, бид наадахын чинь тухай юу ч мэдэхгүй, харин ч и л тэр зурвасыг авсан байна, ч и л Костятай бичгээр харилцах арга олсон байна. Тийм учраас чи наадахаа эсвэл урж хая, эсвэл жорлонд хий, эс тэгвэл өөрөө хэрэгт орооцолдоно шүү. Би энэ зурвасыг чамд өгсөн нь үнэн. Лева, Рина хоёр энэ тухай мэднэ, тэр бас үнэн. Харин чи зурвасыг илчилвэл бид гурав хуу үгүйсгэчихнэ. Бид нарт итгэнэ, бид нар гурвуулаа, чи ганцаараа, бид гурав Костяг таних төдий мэднэ, чи бол түүний эхнэр байсан хүн. Энэ зурвасыг бидэнд биш, чамд бичсэн байна.

-Одоо л ойлголоо гэж Варя өгүүлэв. -Ер нь ч би яг тэгж л бодож байсан юм. Тэр ч байтугай, эцэг болсон ивээн тэтгэгчээ зовлонд унахаар нь зоргонд нь хаяж байна гэж дургүй хүрч байсныг яана. Тэгсэн чинь хаяагүй байх нь. Гэхдээ хүний түрийвчээр харж үзэх нь. Миний

түрийвчээр. Тэрний ямар ямар гээч эд юмс нь надад байна? Костюм, шаахай, буу энэ тэр нь үү?

-Чамд түүний бэлэглэсэн юмыг хэлж байгаа юм. Лавров чамд пальто хийж өгсөн, зүгээр ч үгүй, нэг биш пальто, Ламанова даашинзнууд, Барковский гоёлын шаахайнууд хийж өгсөн, эд нар чинь шилдэг оёдолчид, шилдэг гуталчин, тэр юмнуудыг зарж болно.

Варя цамцаа тайлж байгаа дүр үзүүлэн,

-Одоо тайчих уу, эсвэл маргааш ажил дээрээ тайчих уу? гэв.

-Варя ингэхийн хэрэг юу байна? гэж Лева аргадахыг оролдов.

-Харин тийм гээд Варя цамцаа засав. -Тэгэх тусмаа энэ миний цамц юм чинь. Мирон, чи одоо тогтоож ав, сайн тогтоож аваарай, та хоёр ч бас сайн тогтоож ав. Костя бид хоёр салахад хөхний даруулганаас бусад бүх юмыг би түүнд орхисон. Одоо хөхний нэг даруулга нь бүтэн байгаа, тэрийг өгч болно. Гэхдээ одоо биш, би өөр даруулгатай яваа.

-Костяд худлаа хэлэхийн хэрэг юу байна? гэж Мирон хөмсөг зангидав. -түүнд өмгөөлөгч хэрэгтэй, мөнгө хайж байна, тэгээд чамайг тодорхой зүйл борлуулж чадна гэж үзэж байна. Чи үнэхээр бүх юмаа түүнд орхисон бол тэр юу гэж дэмий цаг ингэж үрж байхав, тэр чинь аж и л х э р э г ч хүн шүү дээ. Мөнгө байхгүй газраас мөнгө хайхгүй. Тэгж тоглож байх цаг түүнд байхгүй. Шүүх хурал маргааш, нөгөөдөргүй болох гэж байна.

-Туслах арга алга даа.

-За яахав, түүнд тэгж л уламжлая гэж Мирон сүрдүүлэв.

-Харин битгий сүрдүүл, би сүрдүүлэхээс айдаг хүн биш. Костя олон хүүхнийхээ нэгтэй л намайг андуурч. Шоронгийн хүнд бодох цаг дутах биш, тэр хүүхнээ яг санаг л дээ.

Хөгжим дахиад тоглолоо.

-Варя, хоюулаа бүжиглэе.

Варя хормын төдийд тээнэгэлзэв. Эд нар юу бодож олсон бол? Мирон, Рина хоёр энд үлдэж байгаад бас нэг балай юм тулгах гээ юм уу? Левочка өөртэй нь ярилцах гээ юм уу?

Варя босч, Левагаас түрүүлэхийн бүжгийн хүрээ рүү зүглэв. түүний хамгийн дуртай тангоны ая явж байна. Энэ аяыг олон удаа сонссон боловч зөвхөн Сашатай “Арбатын нүх”-энд гурван жилийн өмнө энэ аянд бүжиглэсэнээ сав л хийвэл санадаг билээ. Ээ, бурхан минь! Гурван жил! Саша өөртэй нь хэдийвээр яриагүй ч гэсэн хамаг бодол санаа, хүсэл зориг нь түүнтэй цуг байгаа. Харин энд бол Костягийн бүлэг л байна, Костя өөрөө толгойлогч нь, шоронд байхад нь хүртэл эд нар нь үг дуугүй захирагдаж байна. Тушаалыг нь биелүүлж байна. Тэр өөрөөс нь юу хүсч байгаа юм бол? Өмгөөлөгчийн мөнгө олж өгнө гэж бодоо юу? Тэр дэмий, өөрт нь мөнгө байхгүйг маш сайн мэднэ. Эсвэл зарж борлуулчих новш үлдсэн гэж үнэхээр итгэж байгаа юм болов уу? Зүгээр л эрүүгийн ялтны зуршил биз. Эрх чөлөөтэй

явахдаа хоносон хүүхэн болгон нь одоо түүний талаар санаа тавьж, эргэж тойрох ёстой байх нь. Өөрийгөө мундаг урт гартай гэж бодож байх нь. Надад тэр гар хүрэхгүй, үгүй! Мирон, яая гэхэв, Костягийн гарын нохой. Рина нууц амраг нь байсан ухаантай. Гэтэл Левочка? Эелдэг, эвлэгхэн Левочка? Үнэхээр энэ бас түүний гар хөл үү? Одоо энэ өөртэй нь бүжиглэж буй хөөрхөн залуу, өөртэй нь хоёр жил нэг өрөөнд хамт ажиллаж байгаа, дотор нь ороод гарсан юм шиг мэддэг энэ Левочка тэр балиар хэрэг явдалд бас оролцдог байх нь уу?

Варя тэгж бодсоноо,

-Энэ явдлын тухай чи юу гэж бодож байна гэж асуув.

-Чи намайг битгий илчлээрэй хэмээн Левочка ялдамхан инээмсэглэв. Тэгснээс болоод хөндлөнгөөс харахад тэр хоёр ойр зуурхны юм ярьж байна гэлтэй. -Илчлэхгүй биз? Чи ам өчиг өг!

-Ам өчгөө өгье. Ёстой нээрэн шүү.

-Мирон Костяг шоронгоос аврах ёстой болчихоод байгаа юм. Эс тэгвэл шүүх хурал дээр Мироныг бас шоронд хийхээр юм илрэнэ. Тийм учраас Костяд өмгөөлөгч хэрэгтэй. Гэтэл мөнгө нь дутаад, энэ Мирон түүний танилууд руу харайлгаж байгаа юм, бильярдчид, энгэр зөрүүлсэн хүүхнүүд, түүгээр ч барахгүй, Рина бид хоёроос хүртэл мөнгө нэхсэн.

-Миронд өөрт нь мөнгө байдаггүй юм уу?

-Байхгүй. Уул нь эд нар мөнгөөр барьцаалж гаргах гээд хамаг мөнгөө өгчихсөн чинь хүрээгүй юм.

-Ер нь Костяд ямар ял тулгаад байгаа юм?

-Нэг хүрээлэнгийн ямар нэг ажил байх, том гэрээ хийгээд, олзоо зарим нэг хүнтэй хуваасан чинь, хажуугийнх нь хүмүүс хов хүргэчихэж, товчдоо, муухай хэрэг, тэгээд Мирон мэрийгээд байгаа юм. Өөрийнх нь хэрэг мандаж мэднэ.

-За, чи энэ Миронд надаас юм горьдоод хэрэггүй гэж хэлээрэй, намайг тайван орхиг, орхихгүй бол түмэн амьтны нүдэн дээр нүүрийг нь хуу урна гэж мэдээрэй. Ер нь чи намайг ийш нь дэмий чирч ирсэн байна.

Сергей Алексеевичид захидлаар харилцах эрхгүйгээр арван жил хорих ял заажээ. Энэ ялны тухай Феня ярьсан юм. Тэрээр гал тогоонд уйлж унжаад салахаа больж.

Энэ гаслаан, үглээнийг тэсэхийн арга алга. Сергей Алексеевич, Феня, тэднийх гурав ийм ойр холбоогүй байсан бол Вадим энэ бүхнийг тэсээд өнгөрөөх байсан биз. Гэтэл үүнд санаа нь зовоод болж өгөх биш. Ямар нэг мэдээ тарсан байхыг хэн байг гэхэв, шоронгоос гарсан хэн нэгнээр авгай хүүхдэдээ юу эс хэлүүлсэн байхыг үгүйсгэхийн аргагүй.

Вадим Арбатаар явахдаа айна, байшингийнхаа орц руу ирэхдээ бүр их айна. Сергей Алексеевичийн аль нэг хүү үүдэнд нь отож байгаад толгой руу нэг юмаар дэлсчих гээд байх шиг санагдана. Тэгвэл, тэгээд л гүйцэх нь тэр! Ер нь тэдний хөвүүдээс л юунаас ч илүү айна. Хоёр хүдэр эр бий. Ах нь сантехникийн слесарь, эдний байшин өөрийн слесарьтай байтал, Феня юухан засуулах хэрэг гарвал түүнийг дууддаг юм. Ингэж дуудахыг нь хоригловол хий сэжиг төрүүлэхийн нэмэр. Нөгөө бага хүү нь цахилгаан шатны засварын мастер, багадаа нүгэлтэй сахилгагүй байсан, одоо ч гэсэн дээрдээгүй бас мангар эр бий. Нэр нь Колька, үгүй ээ, Витька ч бил үү. Хэрэвзаяа ямар нэг цуу тэдний сонорт хүрэх юм бол Вадим сайнаа үзэхгүй, бусдын гараар л авсалчихна, муусайн дээрэмчид!

Сергей Алексеевичийг санагдуулах юмгүй болохын тулд Феняг халахаас өөр зөв шийдэл алга. Ер нь ч түүнийг гэртээ барьж байх нь одоон цагт аюултай. Хамаатан нь шоронд байгаа юм чинь. Харин яасхийж халах вэ? Эцэг нь түүнд дасчихсан, Феня эцгийнх нь зан аяг, дур сонирхлыг мэднэ, хоол ундыг нь сайхан тааруулж, өмсөх зүүхийг нь хүртэл харж хандана, чухамдаа нэг гэрийн хүмүүс. Эцэг нь яасан ч зөвшөөрөхгүй дээ. Уул нь орны хүн олж ядах юмгүй байгаа. Нам, улсын томчуулыг хоморголон барьж байгаа болохоор дадлага сургууль сайтай, ажилгүй өч төчнөөн үйлчлэгч Москвад тэнэж яваа.

Феняг халах асуудлыг эцэг нь сонсохыг ч хүссэнгүй.

-Тэр үсчин чинь Фенягийн хамаатан, тэгэхээр түүнийг ч барих гээд ирж мэднэ, чи ойлгооч хэмээн Вадим эцгийгээ ятгаж гарав. -Айсандаа болоод манай тухай юу ярихыг хэн мэдэхэв. Вика Парист байна, манайхаар гадаадынхан орж гардаг, чамаар эмчлүүлж байсан олон хүн шоронд орсон, зарим нь бүр буудан авсан. Юуны төлөө аз туршиж суух вэ? Бид нар ямар түүнийг гудамжинд гаргаад хаячих гэж байгаа биш, ийм туршлагатай үйлчлэгч чинь дорхноо ажил олно. Өөрсдөө түүнээс дутахгүй мэрэгшсэн хүн олоод авья.

-Би Фенягийн гараар идээшсэн хүн, түүнд итгэдэг, гэртээ шинэ хүн оруулахыг хүсэхгүй байна.

-Өнөө үед шинэ хүн хуучнаас мянга дахин илүү, янз бүрийн юм боллоо гэхэд, “би тун саяхнаас эднийд ажиллаж байгаа, надад мэдэх юм байхгүй” гэж хэлнэ хэмээн Вадим зүтгэв.

-Үгүй, больё чи минь, хий уймрах хэрэггүй, үгүйдээн гэр орондоо ч болохноо тайван байхыг бодож байна гэж Андрей Андреевич зөрөв. -Кремлийн эмнэлэгт Ленин, Сталиныг эмчилж байсан эмч нарын тэн хагас нь шоронд орчихлоо. Левин, Плетнев, Абрикосов энэ тэр. Ямар

чин шудрага, ямар жудагтай, ямар нарийн мэрэгшсэн эмч нар билээ дээ. Маргааш гэхэд надад ч ямар нэг юм зохиогоод тулгачихаж мэднэ. Урьд шөнө хэнийг шоронд хийснийг одоо хэлнэ дээ гэсэн ганцхан бодолтой өглөө ажил руугаа очиж байна шүү дээ. Нээрэн, тэгтэл үнэмшихийн аргагүй юм сонсож байгаа юм чинь. Дахин хэлэхэд, би тайван байхыг хүсч байна, би Феняд нэгэнт дассан, тэр ч бидэнд үнэнч хүн, шинэ хүнтэй болохыг хүсэхгүй байна.

-Тэгвэл яая гэхэв. Чи тэгж шийдсэн бол түүгээр чинь больё. Чи өглөө эрт гарч, үдэш орой ирдэг, өдөржин ажил дээрээ байдаг болохоор чамд амар байгаа. Гэтэл миний ажлын байр чинь энэ гэр, тэгээд Фенягийн өдөржин гаслахыг юм уу, Сергей Алексеевичийн авгайтай дэмий ярьж, усан нүдэлж, гомдол санал тавихыг сонсон байж ажил хийнэ гэдэг бол, өршөөгөөрэй, давдаг даваа биш.

Андрей Андреевич хүү рүүгээ хөмсөг зангидан харснаа,

-хүн амьтанд, үгүйдээн, зовлонгоо эдлэх эрх үлдээ л дээ гэж нухацтай бөгөөд шазруун хэлэв.

Юу хэлэх гээд юу хэлж байна вэ? Засаг баригчидтай Вадимыг нэг эгнээнд тавьж, засагт дургүй байдгаа түүнийг дайруулж хэлж байна уу?.. Чухамдаа тэр хоёрын харьцаа хөрсөөр удаж байгаа, Вика хүнтэй сууж, Вадим байраа солино гэж айлгасан үеэс үү, эсвэл Вадимын Камерын театрын тухай өгүүлэл бичсэн үеэс үү.

Өгүүллүүд нь эцгийнх нь сэтгэлд нийцдэггүйг Вадим, мэдээж, ойлголгүй яахав. Гэхдээ шудрага байх хэрэгтэй шүү дээ: Хүү чинь үзгээрээ засагт зүтгэж байгаа нь сэтгэлд таарахгүй байгаа бол бусдыг бас адилхан үзэж, жишээлбэл, нөгөө Немирович-Данченкотой харьцаагаа таслах хэрэгтэй. Станиславский тэр хоёр засагт зүтгээгүй гэж үү? Эсвэл хуучин анги зайлшгүй мөхөж, шинэ нь мандан бадрах тавилантайг “Турбиныхны өдөр хоног”-т үзүүлсэн чинь тэр хоёр биш юм уу? Бас яагаад Погодинтой хамт “Буутай хүн”-ий сургуулилт дээр очив? Хэдэн жил театр руу зүглээгүй хэрнээ Погодиныг дагаад хөл алдчихсан. Бас Михаил Роммтой бөөн баяр болчихоод утсаар бурна. Гэтэл Вадим түүний “Ленин аравдугаар сард” киноны материалыг Мосфильм дээр үзээд, түүхийг яаж ингэж гуйвуулж болно оо! гэхээс нүдэндээ итгэж ядан байсан билээ. Ингэхэд, одоо түүх гуйвуулахыг хэн цээрлэж байгаа билээ дээ? Сталиныг хүн толгойтой бүхэн шагшин магтаж байна. Жирийн хүмүүс хүртэл төрсөн өдрийн баяр хийхдээ, эхлээд Сталины эрүүл мэндийн төлөө хундага өргөж, дараа нь нөгөө хүнийхээ төлөө өргөдөг маяг дэлгэрээд байна. Зүйтэй шүү дээ, тэгэхээс яахав. Энэ үүднээс үзвэл мань хүн ч бусдаас ялгарах юм юу ч алга.

Эцэг ямар нэг юм арай дуулчихаагүй байгаа даа? Дуулах ёсгүй дээ! Үгүй, эцэг нь ДЯАК-ын эмнэлэгт зөвлөлгөө өгдөг юм чинь, аль нэг том дарга нь танай хүү эр хүн, бид сэтгэл хангалуун байгаа гэх ухааны юм дурсчихсан байж магадгүй... Хүү чинь “манайх” юм чинь та ч “манайх” гэж “өөрснийхэнтэйгээ” ярьж буй мэт саймширсан байж мэднэ... Танд итгэж байгаа, Кремлийн эрүүл мэндийн газрынхныг хуу барьсан, гэтэл таныг хөндөөгүй... Эсвэл нэг дээгүүр зиндааны барлагтай таараад, архаг хуучинсаг байдлаараа дургүйг нь хүргэж, цаадах нь улайм цайм, “чи зөнөг толгой, хэрээ мэдээрэй, хүү чинь бидэнд туслаж байгаа, чи ч гэсэн тусал, биднийг эмчил, битгий сагсуур” гэж шууд барлагтсан биз. Тэгээд эцэг нь Вадимыг ДЯАК-тай сайн харилцаатай юм байна гээд ойлгочихож. Мэдээж, юу гэж баярлахав.

Хуучин цагийн жудагтай аливаа хүнд ДЯАК бол харгис цагдаагийн газар гэсэн үг, энэ байгууллагатай тогтоосон холбоо сүлбээ, харилцаа бол байж боломгүй зохисгүй зүйл.

Тийм мэдээ сонссон бол ч эцгийнх нь цус багагүй муудаж таараа. Яаж өсгөж бойжууллаа, гэтэл нөгөө сайн хүүг нь мэдээлэгч болгочихож. Ийм зовлонд, ийм сүйрэлд орсон хүүгээ харин ч өрөвдөх ёстой юм биш үү. Чухамхүү сайныг нь, аль цагаан цайлганыг нь одоо ингэж нугалж байгаа шүү дээ. Эцэг нь энэ улсад ямар ганц жил аж төрж байгаа биш, Аюулаас хамгаалахынхантай хэн ч сайн дураараа хамтарч ажилладаггүйг мэднэ. Тэгвэл өрөвдөөч дээ! Байхгүй шүү, сэтгэл нь эвэршсэнийх дээ, хөөрхий. Гэвч эцсийн удаа бас нэг ятгаад үзэх хэрэгтэй.

-Аав аа, хоюул маргалдахаа больё, уужуу тайван ярилцъя. Намайг хулчгар амьтан биш гэж чи мэднэ, гэхдээ улс орон даяар үхлийн хар шуурга тавих мэт орчин тойронд юу болж байгааг чи харж байна. Өнөөдөр гэнэдлээ л бол маргааш засна залруулна гэж байхгүй. Хагас жилийн өмнө, жишээ нь, би Фенягийн тухай чамтай ярих байсан уу? Харин одоо, энэ олон шүүн таслах ажиллагааны дараа би айгаад байна, чиний өмнөөс ч айж байна, өөрийнхөө өмнөөс ч айж байна.

Андрей Андреевич дуугарсангүй. Энэ бол муугийн дохио биш, лав эргэлзэж эхлэв бололтой.

-Чамаас ойр дотно хүн хорвоо дээр надад байх биш хэмээн Вадимын хоолой зангирав. -Юу л даа, би чамд ярьж байгаагүй, би ээжийг бараг санадаггүй юм. Аливаа дурсамж маань чамтай л холбоотой. Зуслан дээр нэг удаа ээж жимсний чанамал хийж, би дэргэд нь сууж байтал намайг хэдгэнэ хатгачихсаныг, яагаад ч юм, санадаг юм... Бас өөжинд бүүвэйлж байсан санагдах юм... Ээж чамаас өндөр юм шиг санагддаг байсан, тийм үү?

-Үгүй ээ, бид хоёр нуруугаар чацуу.

-Ээжийг австай хэвгэж байхад хонгилын толийг хар алчуураар бүтээчихсэн, би тийшээ гарахаас айгаад байснаа санах юм... Тэгээд дараа нь нөгөө Владислава Леопольдовна гэж нэг мам манайд ирсэн, нэрийг нь хэлэх гэж би ёстой зүдэрдэг сэн.

Ээжийг нь нас барсны дараа, эцгийнх нь холын хамаатан Владислава Леопольдовнаг Вика тэр хоёрын асрагчаар авсан билээ. түүний вандан орыг чухамхүү Вадимын өрөөнд оруулж тавьснаас болж, Тэрээр тэр авгайд дургүй болсон юм. Ганц минут наана ч үгүй, цаана ч үгүй, яг найман цагт гэрэл унтрааж Вадимыг оронд нь оруулна. Тэгээд заавал гэдрэг нь харуулж хэвгүүлээд, хоёр гарыг нь хөнжлийн гадуур гаргуулна.

-Би яагаад заавал ингэж унтах ёстой юм? гэж Тэрээр асуусан. мань хүн уул нь гараа дэрлээд, атирч унтах дуртай.

-Муу зан суудаггүй юм гэж Владислава тайлбарласан.

мань хүн юу ч ойлгоогүй.

Өглөө шүдээ угаахыг нь хүртэл хянана. “Чи ах нь учраас дүүдээ бүх юмаар үлгэр үзүүлэх

ёстой” гэх. Цайгаа бүтээлэг, хувцас руугаа асгах вий гэнэ. Салхинд авч гарахаараа заавал өөртэйгөө зэрэгцүүлж явуулна. Дараа нь хичээл хийлгэнэ, Викагаар зураг зуруулна, Вадимд үсэгтэй шоогоор үг бүтээхийг заана. Залхуурах юм уу, алдаа гаргавал заавал шийтгэнэ.

Феня аминд орж билээ. Нэг удаа хичээлийн үеэр луувангийн шүүс авчирч өгөхдөө, Владислава Вадимын чихийг мушгиж байгааг харчихаад,

-Та яагаад манай хүүхдийг эрэмдэглээд байна? Наадах чинь ингүүлж сураагүй хүүхэд гэж бөөн дуу шуу болсон.

Феняг өмөөрөнгүүт Вадим сүр бадруулан уйлж, шалан дээр унан тийчилж гарсан. Феня энэ тухай эцэгт нь хэлсэн байх, ямар ч атугай, тэднийг орой салхинд гараад ирэхэд, нөгөө орыг түүний өрөөнөөс гаргачихсан байсан, Владислава авгай ч Мытищи рүү бил үү, Лосиноостровск бил үү, гэр рүүгээ үүрд тонилж арилсан юм даг.

-Ингэхэд, тэр авгай таны юу байсан юм бэ?

-Нагац эгч гээд эцэг нь инээмсэглэв.

Аавыгаа инээмсэглэсэнд Вадим бүр урамшив.

-Чи намайг Феняд чамаас хөндий гэж бодож байна, тийм биш, аав аа, би ч Феняд их дассан хүн. Гэхдээ сэтгэлээс ухаан давамгайлах ёстой болдог мөч ирэх гэж бий. Бид нар нарийн төвөгтэй, хүнд хүчир цаг үед аж төрж байна. Бид социалист байгуулалтын амжилтыг үгүйсгэж чадахгүй, энэ бол хэн бүхний өмнө ил байгаа зүйл. Гэхдээ империализмын аюулыг бас үгүйсгэж болохгүй. Энэ бол зайлшгүй зүйл: түүхэнд анхны орон, дэлхийн цорын ганц социалист гүрэн дайсны хүрээлэлд байна... Манай хамаг үрлэг үүнээс болж байна, “гарзгүй олз байдаггүй” гэдэг шиг.

-Үгүй ээ, больж үз, боль! хэмээн Андрей Андреевич дэлбэрэх мэт шатчих нь тэр. -Наад гашилсан бохио өөрснөө нь зажилцгаа! “Империализмын аюул”, “гарзгүй олз байдаггүй”... Дахиад ийм юм надад хэзээ ч бүү хэл, бас Феня өөр газар хайх ёстой гэж надад дахин бүү хэл!

Вадим эцгийгээ ингэж уурлаж байхыг мөн ч олон жил хараагүй дээ. Босч өрөө рүүгээ явахыг завдав.

-Суу, би гүйцээгүй байна гээд Андрей Андреевич хэсэг зуур чимээгүй болж, амьсгаагаа дарснаа хүү рүүгээ эгцлэн харав. -Хэрвээ намайг баривчилвал чамайг цаашдаа яана даа гэж би, мэдээж, бодолгүй яахав. Тэгээд би санаа зовохгүй байж болох юм гэсэн дүгнэлт хийсэн. Чи тодорхой хэмжээгээр хөл чинь дөрөөнд, гар чинь ганзаганд хүрсэн хүн, тийм учраас энэ лай чиний хажуугаар өнгөрнө гэж найдаж байна.

Шарок арван хоёрдугаар сард Москвагийн хаяа руу зусланд шилжиж, хуучин багшаараа хэлээ заалгаж, өөр зааварлагчтай тусгай бэлтгэлээ хийж эхлэв. Парисын шинэ сонингууд, Шпигель-гласын ялгасан ном, ОНЦХ-ны тухай материалыг хоёроос гурав хоногт нэг удаа түүнд авчирч өгнө.

“Локомотив” нийгэмлэгийн спортын бааз тэндээс холгүй байх бөгөөд, тэдний цаначид модон дундуур цанын сайхан зам гаргасан тул Шарок үдийн хоолны дараа хоёр цаг цанаар явна. Зуслангийн байранд өөрөөс нь гадна хоёр хятад, нэг вьетнам шиг хүн, нэг европ, норвег юм уу, швед хүн байлаа. Европ хүн хоёр хятадтай англиар ярьцгаана, Шарок вьетнамтай хоёр гурван франц үг солилцоно. Тэр дөрөв дөрвүүлээ орос хэлэнд муу. Зөвхөн өдөр, оройн хоолон дээр л уулзацгаана, нөгөө швед юм уу, норвегийг Арвид гэнэ, мэдээж, жинхэнэ нэр нь биш, Шарок тэр хоёр цанаар цуг явцгаана. Арвид цанаар явах гэж сэвэлзүүлж өгнө, Шарок арваад жил цана хөлдөө зүүгээгүй болохоор, битгий хүлээ гэж түүн рүү дохьчихоод, явах газар явж, зогсох газар зогсож, бодолд автан тааваараа гэлдрүүлнэ...

Шпигельглас тэр хоёрын сүүлчийн яриа байдлыг тодорхой болгох шиг болсон билээ. Гэтэл гадаад хэлтэст шилжсэндээ өөрөө сэтгэл дүүрэн байгаа эсэхээ нэг л ойлгож өгдөггүй. Ежов түүнийг санаандгүй шилжүүлээгүй нь мэдээж. хэн нэгний оронд тавих гэсэн хэрэг. Гэтэл тэнд ямар ч албан тушаалд тагнуулч хүн хэрэгтэй. Хаашаа ч явдаггүй, Москвад суурин ажилтай ч бай, заавал мэргэжлийн хүн байх ёстой. Тэдэнтэй жишвэл мань хүн шатрын хүү, энэ чиглэлээр мэргэшил нь тэг гэсэн үг, алдаа мадаг гаргаж цөхөхгүй, алдаа гаргалаа л бол цаад жинхэнэ тагнуулчид нь дор нь ашиглана, далимдуулна, ийм ажлын алдаа чинь толгойны үнэнд хүрч мэднэ.

Үүл задран, цас туяараад ирэхүйд Шарок нар руу нүүрээ эргүүлж, саравчтай малгайгаа урагш нь дарж нүдээ таглав...

Амьдрал аа гэж сайхан эд юм даа... Даанч бузарлаж, буртаглаж, түйвээн бусниулчихсанаас биш... Нөмрөн айсуй аюулын дохио сэтгэл зүрхийг нь гэнэтхэн эзэмдээд ирлээ.

Хуучин ажил нь одооныхоос хэцүү ч, Тэрээр тэнд байхдаа хүүхэд ахуйгаас үзэн яддаг хүмүүсээ, нөгөө “Ленинч гвардийнхан” гэгддэг ахмад большевикууд буюу Орос орныг хөнөөгчдийг устгаж байсан, аян хамтад нь Октябрийн хувьсгал хийсэн элдэв еврей, латви, польшуудыг нядааж байсан. Мэдээж, хувьсгалын нэрээр, коммунист намын нэрээр устгаж байсан, гэхдээ асуудлын гол нь энэ биш, чухамхүү тэднийг устгаж байсан нь л чухал зүйл. Энд, гадаад хэлтэст, оросууд бараг байхгүй нь бас үнэн. Еврей, латви, польш, герман, румынчууд байгаа, тагнуулчдын дунд скандинавынхан, испани, франц, англичууд бий. Тэгэхээр мань хүн энд ч гэсэн энэ еврей, герман, польшуудтай нийлж жинхэнэ орос хүмүүсийн эсрэг тэмцэх болж байна. Яагаад гэвэл ОНЦХ-ныхон бол жинхэнэ орос хүмүүс. Хэдийгээр гэнэн, зөрүүд ч гэсэн муу ч, сайн ч орос хүмүүс. Гэтэл тэмцэхээс өөр арга байхгүй, бултах газар алга, тэд нар тэнэг толгойнууд, өөрсдөө зодолдох гэж дайраад байгаа юм. хэнтэй зодолдоно гээч?

Гүрэнтэй! Хохь нь, тэгээд баларцгааг!

Шарок зуслангийн байр руу шилжихээс өмнө нэг базаахгүй мэдээ сонсчээ: Аюулаас хамгаалах газрын Молчановын болон бусад хэлтсийн ажилтан нараас баривчилж эхэлсэн гэж. Одоохондоо бөөнөөр биш, ганц нэгээр нь барьсан, гэхдээ л, ямар ч атугай, эхлэх нь энэ. Шарокийн сэтгэл түгшилгүй яахав. Кировын хэрэг яаж дууссаныг Тэрээр мартаагүй. Зөв, буруу гэж ялгалгүй, үзсэн харсан хүмүүсийг төдийгүй, энэ хэргийг мэдэж байсан, эсвэл чихний үзүүрээр сонссон хэнийг ч бай, түүгээр үл барам, энэ тухай гадарлаж магадгүй гэх бүх хүнийг хуу шүүрдсэн билээ. Гэрч нэг ч үлдээгүй. Цаашдаа ч тийм л байх нь. Харин гадаад хэлтсийг хөндөхгүй байна. Тусгай, нарийн ажилтай хэлтэс. Энд кировынх шиг арга хэмжээ явагдахгүй, ер нь арга хэмжээ зохиодог газар биш, эндхийнхэн өөр ажилтай. Тийм учраас алдаа л гаргачихгүй бол энд аюул багатай. Чухам энэ учраас Ежов түүнийг ийш нь шилжүүлэв үү?

Тэгэнгүүт Шарокийн толгойд нэгэн бодол зурсхийлээ.

“Ажигла”-Ежовын хэлсэн гол юм энэ байх нь. Бас “хуучин ажилтнууд яаж ажилладгийг хар” гэсэн. “Ахмад нөхөд” гээгүй, “туршлагатай тагнуулчид” гээгүй, чухамхүү “хуучин ажилтнууд” гэж хэлсэн. Тэгэхээр, “хуучин ажилтнууд яаж ажилладгийг ажигла...” гэсэн байх нь. Гадаад хэлтэст нэг хүний оронд мань эрийг тавих нь. Үүний өмнө Ежов түүнээс “хуучин ажилтнуудын” ажлын тухай тайлан шаардаж таарна. Тийм учраас Слуцкий, Шпигельглас хоёр түүнтэй их цэнэж харьцаж. Мэдээж, урьдчилан сэргийлэх алхмаа бодогцгоож байгаа. Өөрсдийг нь устгахаас өрсөж, Шарокийг цааш нь харуулах гэж оролдоно. мань хүн ийм ангальд орчихсон юм байна шүү дээ!..

За яахав, харъя! Шарок малгайгаа тэгшлээд, цанын замаар цаашлав.

Шарок зуслан дээр иймэрхүү янзтай өдөр хоног өнгөрүүлнэ... Калугад томиллолтоор яваа дүр гарган, тэндээс ярьж байгаа мэт гэр рүүгээ хааяа утасдаж, хоёр хөгшний биеийг сураглана. Каляд утасдаж, удахгүй очно гэж амлав.

Нэг удаа төвөөс оёдолчин ирж, түүнээс хэмжээ авч, баахан шуухитнаж, бүртгэнэв.

-Танд костюм хийж өгнө.

Сахлаа хусахгүй болохоор эвгүй оргино, нэмэрт нь эрүү нь загатнана. Толинд өөрийгөө хараад гутрах нь халаг. Тэг тэгсээр загатнах нь болив. Дахиад нэг, хоёр долоо хоночихвол эрүүний нь сахал овоо болчих шинжтэй. Арай түргэн ургасан дээд уруулын сахал нь өтгөн, зөөлөн болоод ч тэр үү, өөрт нь хүртэл аятайхан санагдана. Үгүйлэгдэж байгаа юм нь, мэдээж, Каля. Хамгийн хэцүү нь ч энэ.

Гуравдугаар сарын дундуур зуслан дээр нэг машин ирж, жолооч нь Шарокийг хайж олоод,

-Таныг юмаа аваад, хэлтэс дээр ир гэж тушаасан. Би таныг хүргэж өгнө гэж мэдэгдэв.

Шпигельглас түүнийг өрөөндөө хүлээж байв. мань хүн нэг товчлуур дарсан уу, үгүй юу,

Шарок сайн анзаарсангүй, ямар ч гэсэн, нэг энгийн хувцастай хүн орж ирсэн нь үсчин болж таарав. Шарокийг сонжин харснаа, Шпигельглас нэг дугаар хэлээд, халааснаасаа багц карт гаргаж, түүний өмнө дэлгэснээ нэг рүү нь хуруугаараа заав.

Шпигельглас түүнийг тонгойн харснаа, Шарок руу харц шилжүүлж,

-Болно! гэв.

Үсчин ширээн дээрээс картаа цуглуулж, халаасандаа хийв.

-Энэ хүнтэй яв, таны сахлыг янзалж өгнө гэж Шпигельглас хэлэв.

Үсчний жижигхэн өрөөны сандлаас босонгуут Шарок өөрийгөө толинд сайн ажиглав: Цэнхэр нүдтэй, тамхинд шарлаагүй шар сахалтай, эрүүндээ эвлэгхэн бахалтай, шаргал халимгаа хагалж самнасан, гуч гаруй насны сайхан эр зогсож байв аа. Хэдийгээр ахимаг юм шиг болчихсон ч өөртөө аятайхан харагдаж, Шарок мушилзав.

Үсчин нь сэтгэл хангалуун байгаа бололтой, түүнийг оёдолчинд хүргэж өгөв. Зуслан дээр очсон толиотой бүдүүн польш мөн байна. Шидсэн костюмаа өмсгөөд, энд тэндхэн шохойгоор зурж, зарим нэг газар сүлбээрэн зүүгээр хатгачихаад буцааж тайлахдаа,

-Нөгөөдөр бэлэн болно гэв.

Шарокийн дүр Шпигельгласийн сэтгэлд нийцэх шиг болов.

-Оёдолчин танд өмсгөлийг чинь өгөхөөр, гутал, нүдний шил энэ тэрийн хамт шүү, таны зургийг авна. Одоо ингэнэ дээ...

Тэрээр ширээнийхээ нүднээс хавгаст хэрэг гаргаж, доторхийг нь эргүүлж үзээд, хавтсаа хааж, Шарок руу түлхэв.

-Энэ бол ОНЦХ дахь манай тагнуулчдын хэрэг. Би одоо явна. Та миний өрөөнд үлдээд, энэ материалыг уншаарай. Утас дуугарвал битгий аваарай. хүн саад хийж магадгүй, би гаднаас түгжчихье. Хэрвээ жорлонд орох хэрэг гарвал энэ байна.

Шпигельглас номын шүүгээний хаалгыг татсан чинь тэр нь жорлонгийн хаалга болж таарав.

Цагаа харснаа,

-Би таван цагт ирнэ. Юу ч бичиж тэмдэглэж болохгүйг та ойлгож байгаа. Гол зүйлийг тогтоож авахыг хичээгээрэй гэв.

Цоож торхийлээ.

Шарок ширээний ард суугаад, хавтсаа нээлээ.

Энэ хэрэг нь Парис дахь ОНЦХ-ны орлогч дарга, “Фермчин” хочтой генерал Николай

Владимирович Скоблин, түүний эхнэр, орос дууны нэрт дуучин, “Фермчиний авгай” хочтой Надежда Васильевна Плевицкая хоёрынх буюу ЕЖ-13 гэсэн дугаартай тагнуулчийн хавгаст хэрэг ажээ.

Саша Москва орох, ээж, Варя хоёртой тэнд уулзах учиргүй болж таарав. Пушкины нас барсны зуун жилийн ойтой холбогдуулан, тэдний автобааз хэдэн машин яаралтай ачаатай Опочка руу явуулжээ. Үүний тулд жолооч нарынх нь паспортыг цуглуулж, нэвтрэх бичиг авсан боловч ганцхан Сашагийн паспортыг буцааж өгчээ. Москвагийн хилийн бүс рүү түүнийг явуулж болохгүй гэнэ. Тэгэхээр Москва руу бүр яаж явуулахав.

Диспетчер Сашад ингэж тайлбарлаад, өрөвдсөн янзтай харж, “Гутрах хэрэггүй, учир нь олодоно...” хэмээн тайтгаруулах гэж оролдов.

-Надад гутарсан юм алга гэж Саша хариулжээ.

Хад мөргүүлж байгаа нь энэ. Гэхдээ өөр бусдаар нэг их шоовдорлогдсон юм алга. Одоохондоо ээлжийн жолоочгүй хэвээр. Тэр нь ч амар юм, эвдрэл гарвал өөрөө л засчихна. Жижүүрийн слесарь олодохгүй, олдвол үнэрхэнэ, засвал хайш яайш хийнэ, дахиад л өөрөө гүйцээж янзлана.

Харин цахилгаанч Артемкиныг бол арга буюу гуйна. түүнийг Володя гэх. Нүдний шилтэй, үлхгэр, бөгтөр хөвүүн, мэргэжилдээ сайн, юм их уншина, ном цуглуулна. Хачирхмаар илэн далангүй яриатай учраас Саша түүнтэй юм ярихгүй, зүгээр л “Аль вэ, Володя, амаа татъя, ажлаа бодъё” гэж цаашлуулсхийн өнгөрөөнө.

Хааш нь явуулахаас хамааран янз янзын ажилд гарна. Туйпуун заводуос усан буудал руу тээвэр хийх нь элбэг. Хааяа хотоос гадагш явна. Зам нь урт учраас энэ бол ашигтай ажил. Гэхдээ Сашаг явуу-лах нь ховор, диспетчер, механик хоёрын “өөрийн” хүн л ихэнхдээ явна. “Өөрснийхэндээ” шинэ машин, шинэ дугуй, амралтын оочер, амралтын бичиг, гавшгайч цол энэ тэрийг түрүүлж өгнө.

Өөр бас булхай бий: Сул зогсоолоо, хоосон явууллаа гэж хэл ам гаргахгүй бол замын хуудсанд баахан худлаа километр бичээд өгчихнө.

Саша энэ мэтээс хөндий явна. Олон нийтийн ажилд идэвхтэй оролцохгүй, хурал дээр үг хэлэхгүй, худлаа зам бичүүлэхгүй. Тийм учраас л мань хүнийг туйпуу, цементэнд явуулна. Ажил нь бохир ч гэсэн сэтгэлд сэвгүй.

Ийм шудрага бус, хуурмаг явдал хаанаас үүсэв ээ? Хуучин ийм юм байгаагүй шүү дээ. Хүмүүс ажлаа мэддэг байж. Одоо дарга нар нь ажлаа мэдэхгүй учраас захиргаанд нь байгаа хүмүүс булхайцаж, өөрийгөө хянах чанар, хүнлэг сэтгэлээ гээж байна.

Сайн юмыг хүртэл шулуухан хийхийн оронд арга заль гаргах болцгоожээ.

Саша Калининд ирсэн анхны өдрөө Людатай хамт очсон нөгөө Иван Феоктистович буюу дархан Пчелинцев нэг өглөө, ээлж эхлэхийн өмнө Саша дээр иржээ.

-Панкратов, чи яагаад намайг хөөдөөд байна?

-Юу болчихоов?

-Гурван сар ажиллаж байгаа хэрнээ үйлдвэрчний гишүүнээ бүртгүүлэхгүй, татвараа төлөхгүй байна шүү дээ.

-Би үйлдвэрчний батлахаа үрэгдүүлчихсэн, ажилд орохдоо хэлсэн шүү дээ. Миний бүх бичиг баримт шинэ, паспорт ч ялгаагүй.

-Үйлдвэрчний хороонд хэлэхгүй яасан юм бэ, шинэ батлах бичиж өгөхгүй юү.

-Ерөөсөө зав болсонгүй.

-Чи завгүй хүн байж, түүнээс чинь болж би буруудаж байна.

-За, уучилж үзээрэй.

-Чамайг одоо үйлдвэрчинд шинээр элсүүлэх хэрэгтэй юм байна. Чи бол хэрэг дээрээ гарчихаж. Би сануулга авч таарна.

Тэгж хэлээд жаахан бодсоноо, хуйвалдах янзтай,

-Чи өргөдөл бич, бичиг баримтаа үрэгдүүлсэн, захиргаанд мэдэгдсэн, шинэ паспорт авсан гэх ухааны юм биччих. Тэгээд үйлдвэрчний батлахаа гээсэн гэхгүй юү. Ямар үйлдвэрчнийх вэ, чи?

-Нийтийн аж ахуйн ажилчдынх.

-Хэдэн оноос?

-Хорин есөн оноос.

-За тэр... Тэгээд л биччих. Бүх юмаа хаячихсан гээд. Ажилд орсон сар өдрөө тавиарай. Дуулав уу?

-Дууллаа. Тэгье.

-Одоо бичээд надад өгчих. Би яг тэр өдрөөр чинь бичээд марк энэ тэрийг чинь наачихъя. Сар болгон ямар цалин авснаа бичээрэй, хоёр, гурав, дөрөвдүгээр сарынх гээд. Батлахаа маргааш аваарай. Харин дэмий яриа хэрэггүй шүү. Дуулав уу?

-Дууллаа.

Маргааш нь Пчелинцев гурван сарын марк наачихсан батлах Сашад үнэхээр гардуулав. Сашагийн яг хэлсэнчлэн 1929 оноос гишүүн гээд биччихэж.

Нэг шил юм, мэдээж, тавилгүй яахав.

Саша долоо хоногт нэг удаа ээж рүүгээ утасдана. Варятай бол дахиж яриагүй. Тэр нэг удаа ярьсны дараа, “Надад өөр хэлмээр юм алга уу, Саша?” гэж асууснаас хойш мань эр уймарч орхисон юм. “Би чамд хайртай” гэж хэлэх байх гэж Варя горьдсон. Гэтэл мань хүн тэгж хэлж чадаагүй. Галт тэрэгний буудал дээр ээжтэйгээ ярилцсаны дараа вагоноор явж байх зуур буцлах юм нь буцлаж, ширгэх юм нь ширгэсэн. Зэрлэг адгуус шиг хардлагад автаж, тавьж түйхгүй цөхөрч байснаа одоо санахаар өөрөөсөө ичдэг билээ. Катя, Зида энэ тэрийн хуучин явдлыг мань хүн сонирхдоггүй байсан. Катя нэг механиктай суух гэж байгаагаа хэлэхэд, өө тийм үү, суулгүй яахав гэхээс өөр юм бодогдоогүй. Гэтэл ангийнх нь хүүхдийн дүү, нэг байшингийнх учраас л тааралддаг тэр охиныг дотор харанхуйлтлаа хардаж байгаа юм. Хардах сэтгэлээ тэгэхэд барьж чадсан төдийгүй хайрлах сэтгэлээ унтрааж чадах шиг санагдсан билээ. Гэтэл барьж чадаагүй, унтрааж чадаагүй болох нь утсаар ярихад мэдэгдсэн. Тэгээгүй бол Калининд ирж, галт тэрэгний буудал дээр цуг жаахан сууя гэхэд нь юу гэж тэгтлээ сандрах вэ дээ. “Тэр бүтэхгүй ээ!” гэж залсан. Ингэж яарснаараа өөрийгөө барьж өгсөн, энэ үг бол түүнтэй уулзахыг хүсэхгүй буйг илэрхийлсэн үг. Хэлсэн шалтаг нь шал тэнэг: “би өдөр нь ажилтай”. Варя өдөр ажилгүй байдаг юм уу? “Тэр бүтэхгүй” гэсний дараа л тэр дуугүй болчихсон. Яг ойлгосон хэрэг. Эцэст нь урамгүй дуугаар гэнэт, “Надад өөр хэлмээр юм алга уу, Саша?” гэж асуусан. Өөрийнх нь толгойд багтахгүй хачин юм болж байна. хүнтэй суугаад, т ү ү н и й өрөөнд аж төрж, т ү ү н и й орон дээр нөхөртэйгөө унтаж, түүнийгээ хайрлаж байж. За яахав, сэтгэл нь хөрсөн гэж саная... Тэгээд газрын мухарт ял заагдсан Сашад шууд хайртай болчихож, э ч н э э г э э р дурлачихаж. Ийм юм гэж байхгүй шүү дээ. Хэрвээ байдаг юм бол тэр бол хайр дурлал биш, гаарсан төсөөлөл, өөрт нь ч яг тийм явдал тохиолдсон юм чинь. Харин тэр хайр сэтгэлийг ээжийнх нь захиан дээр бүсгүйн нэмж бичсэн товчхон үгс тэжээж тэтгэж байсан: “Чиний одоо юу хийж байгааг мэдэхсэн гэхээс би ёстой байж ядаж байна”, “Аж төрж байна, ажлаа хийж байна, санаж байна”, “Бид чамайг хүлээсээр сууна”. Тов тодорхой үгс, цаана нь элдэв далд санаа хайхын ч хэрэг байхгүй. Гэтэл мань хүн хариу бичихдээ буруу ойлгогдчих вий, хий горьдуулчих вий хэмээн үг болгоноо цэгнэн болгоомжилдог байсан. түүний захианаас, “Хонгорхон Варя минь...” гэснээс өөр олох юм түүнд юу ч байгаагүй. Тэгэхээр сайхан мөрөөддөг охин л байна. Хэдтэй билээ дээ? Саша дотроо тооцож үзэв. Хорьтой. Цөллөгний хүнд хайр сэтгэлтэй болсон мэт зохиомжлон бодож, түүнийгээ хүлээж, хожим түүн рүү ухаан жолоогүй харайлгана гэдэг бол хорин насны уран сэтгэмж яах аргагүй мөн. Ердөө л уран сэтгэмж, өөр юу ч биш.

Тэглээ ч гэсэн Варягийн дууг мартаж чаддаггүй. Яваандаа өнгөрөх биз. түүнийх ч өнгөрнө, өөрийнх нь ч өнгөрнө. Үнэхээр ч тэр утасны яриа яван суун мартагдаж, Варятай буруу ярьсандаа гэмших нь багасчээ.

Гэтэл бүр зургаан сард, мань хүн нэг удаа хачин зүүд зүүдэлжээ.

Нөгөө суудаг айлынх нь хаалгыг сэргийлэхийнхэн балбаж, юун хүн тэднийд суудгийг мэдэх гэж хоёр хөгшнийг хаалга онгойлго гэж шаардаад байх шиг.

-Авдранд ороод нуугдчих гэж Матвеевна хэлж байна.

-Би яаж нуугдах вэ, би багтахгүй шүү дээ гэж Саша хэлснээ зогсоо чөлөөгүй хөхрөөд байна гэнэ. Гэтэл хаалга нүдсэн хэвээр, харин сэргийлэх биш, нэг хүүхэн оруулаач гэж гуйж байна. Тэр дууг Варягийнх гэж мань хүн таньжээ.

Саша өглөө нь буцалсан ус аягалах зуур,

-Матвеевна, урьд шөнө та миний зүүдэнд орлоо гэв.

-Ээ, эцэг чинь, яаж?

Саша зүүдээ ярьж өглөө.

-Хаалга нүдсэн бүсгүй чинь чам руу тэмүүлж яваа ганихарсан амьтан байх нь. Чи авдар уу орсон уу, ороогүй юү?

-Юу гэж орохов.

-Тэр чинь сайн байна. Харин инээгээд байсан чинь муу ёр, болгоомжтой байгаарай.

Чавганц ингэж муу амлав. Саша ажил дээрээ очтол Осташков руу, алсын тээврийн зам өгчээ. Тэгээд их замд гараад сайхан сүүгүүлж явгал машин нь гэнэтхэн жолоогоо булааж шарваад, золтой л замын хажуугийн ховил руу орчихсонгүй, аз болж зах дээр нь зогсоож дөнгөв. Тэгсэн чинь нэг дугуй нь хагарчихаж.

Бушуухан бууж, духандаа чийхарсан хөлсийг арчихаад, домкратаа гаргаж, нөөц дугуйгаа тавих гэсэн чинь гар нь ерөөсөө эвлэж өгдөггүй. Газар суугаад, ногоо тасдан зажлав. Санаа бодлоо төвлөрүүлж чадахгүй зөндөөн удаан тийнхүү суулаа.

Хэзээ ч элдэв совинд итгэж яваагүй, тэгэх тусмаа зүүдээ үнэмшинэ гэж юу байхав. Гэтэл чавганц “болгоомжтой байгаарай” гэж сануулсан, “чам руу тэмүүлж яваа ганихарсан амьтан” гэж Варяг онож хэлсэн байж магадгүй.

Саша дугуйгаа сольж тавиад, цаашаа явав. “Чам руу тэмүүлж яваа ганихарсан амьтан...” Чавганцын үг сэтгэлийн шархыг сэдрээж, мань эр нөгөө галт тэргэн дотор шаналж явснаа мартчихаад, дахиад л санаа бодол нь тэнгэрт халин гандирсын балгас сүндэрлүүлж эхлэв. Үгүй, больё чи минь. Варягийн хэлсэн үг, дуу хоолойг хэт үнэлж болохгүй, түүнээс гадна зүүдэндээ итгэнэ гэдэг бол тэнэг хэрэг.

Саша ажлынхаа дараа хааяа нөгөө кафед очно. Тэгээд Людагийн ээлжин дээр таарах нь ч бий. Хүүхэн түүн рүү инээмсэглэн, гараа өргөдөг боловч өөрийнхөө үйлчилдэг ширээ рүү суулгахгүй. Саша хоол идчихээд, Людаг танхимд байвал толгой дохичихоод, байхгүй бол чимээгүй яваад өгнө. Нэг удаа Глебтэй цуг очсонд, Люда тэр хоёрыг өөрийнхөө ширээнд суулгаж үйлчилсэн. Тэд нар мөнгөө төлөөд явсан. Люда сайхан зантай байсан ч Сашаг үлд барь гэгүй.

Тэднийд хэн нэгэн хамаатан нь ирсэн юм болов уу? Эсвэл байрныхан нь Сашаг анзаарчихсан, тэгээд Люда түүнийг гэртээ аваачихаас эмээж байна уу? Харилцаагаа үргэлжлүүлэх хүсэлгүй байгаа нь хожим тодорхой болжээ.

Гайхах юу байхав. Нөгөө дархныд анх очиход мань эрийг суллагдсан хүн гэж гадарлаад хөндийрч суухад нь л Саша түүнийг болгоомжтой хүүхэн юм байна гэж ойлгосон... Харин

өөрийнхөө тухай, хэлмэгдсэн аав, ах хоёрынхоо тухай илэн далангүй ярьсан нь тэр хашир байдалтай нь сайн авцалдахгүй байсан. Аягүй бол, тэр нэгэн үдэш тэгж илэн далангүй ярьснаасаа болоод одоо улам болгоомжилж байж мэднэ.

За яахав! Сайн ч хүүхэн, сайхан ч хүүхэн, дотноссон бол ул мөр үлдэх нь лав, хэцүү цагт таарч, аминд орж, их тус болсон доо. Гэхдээ сэтгэл нэгэнтээ дэврээд л өнгөрөө биз, аль алиных нь хувьд санаандгүй учрал, энэ тухай хоюулаа бүр эхнээсээ л мэдэж байсан юм.

Нөгөөтэйгүүр Людагийн тухай бодож байх зав ч алга. Өдөржин замд шогшуулна, хоногт наад зах нь бүтэн хагас ээлжийн ажил хийж, төлөвлөгөө давуулж биелүүлнэ. Нэмэрт нь ээлж солигдох завсар хурал цуглаан, улс төрийн яриа таниулга хийх нь элбэг, Саша тийм ажлаас дөлдөг болохоор ажлаа хийж яваад хоёр, гурван цаг хоцорч ирнэ. Ажлаас буугаад замын хуудсаа бөглүүлнэ, машинаа угаана, хуучин юм чинь засах ноцолдох юм мундахгүй, тэгээд шүршүүрт орно, хувцсаа солино гэсээр байтал аль хэдийн үдэш болж, кафе хаагдах цаг болчихсон байна.

Саша автобааз дээр хэнтэй ч найзласангүй, харин Глебтэй бол харилцаатай. Тэрээр автобус будах ажлаа дуусч, мөнгөө аваад, Леонидэд ногдох хувийг өгөв. Цаадах нь энэ ажлыг өгсөн болохоор тэр. “Өө, яахав, өөр ажил олно доо, ажил бол араатан биш, зугтаад явчихна гэж байхгүй” хэмээгээд Глеб гуних гудайх царай алга. Сайн залуу. Өвөл дуусчихлаа гэж баахан гаслана. Тэшүүрээр гулгаж чадсангүй гэж тэр. Хоёр жилийн өмнө мужийн аврага болж байсан гэж хөөрөх боловч үнэмлэх, дипломоо эс үзүүлнэ. Төгөлдөр хуур, баян хуур дарна, Вадим Козиныг шүтнэ, Лещенког “нэг л биш...” гээд төдий л тоохгүй.

Төгөлдөр хуураа дараад Козиныг дуурайж дуулах дуртай. Хуур нь хариугүй доройтож хуучирсан эд. Гэрийн эзэгтэй гэх нагац эгч нь бас доройтсон эмгэн. Гэхдээ цэвэрхэн. Айдас хурсан жижигхэн нүд-тэй. Глеб түүнийг “та” гэнэ. Зээгийнхээ дууг сонсох дуртай, өрөөнд нь орж ирвэл Глеб тосч аваад тохойдон байж сандал дээр суулгана.

Байшин нь ч бас хуучин, гэхдээ эмх цэгцтэй, бүгд хаалттай, түгжээтэй, эмгэн хулгайчид, танхайчуулаас их айдаг болохоор ха-шааны хаалга ч түгжээтэй. Өндөр ч гэсэн бас л өгөршиж хуучирсан хашаан дотор ногоогоо цэвэрхэн үелүүлж тарьсан харагдана.

Глеб хотоор нэг танилтай, гэхдээ Сашагаас өөр хэнийг ч гэртээ урихгүй. Архийг хаа тааралдсан газраа, хэнтэй ч хамаагүй ууна, тийм мөртлөө гэртээ хэзээ ч уухгүй. Саша нэг удаа ганц шил юмтай ирсэн чинь Глеб толгой сэгсэрч,

-Үгүй шүү, ялдам минь, би эгчийнхээ дэргэд ганц дусал ч амсахгүй номтой. Харин би чамд дуу дуулж өгье. Вертинскийг дуурайх уу? гэжээ.

Глеб сонсгол үнэнхүү сайн, хэнийг ч бай ёстой адтай дуурайна.

-Глеб, аан гэж бай, чи олны өмнө дуулахад болох юм биш үү гэж Сашаг хэлэхэд, Тэрээр,

-Би юуг ч чадна, чи хар гээд “Гамлет”, “Сайхан Елена”, “Кречинскийн хурим” зэрэг жүжгийн ноорог зураг үзүүлж, эдгээрийг нь Акимов магтсан гэж ярина. Тэр зурагнуудаа сандлын ар

түшүүлж тавиад, жаахан холдож, толгойгоо гэлжийлгэж байгаад л харна.

-Би тэр үед нэг хүүхэнд сэтгэл алдчихсан байсан юм, ялдам минь, нөгөө авьяас, билэг, онгод энэ тэр чинь цөм тэндээс учигтай... Уран бүтээлийн эрч хүч бол бэлгийн эрч хүчний хувирал. Тийм шүү, ялдам минь! Хайр дурлал бол онгодын эх булаг.

-Тэр чинь Репиний “Онгоц чирэгчид”-ээс их тод мэдрэгдэнэ дээ гэж Саша тохуу хийнэ.

-Ялдам минь! Чи битгий тэгж ярь л даа. Чи миний санааг ойлго. Бүх юмны язгуур нь хүний хуялын хүч. Би үүнийг л хэлээд байна. Хуялын хүч нь дууслаа л бол уран бүтээлч дуусах нь тэр.

-Тициан зуу насласан, ажлаа үхэн үхтлээ хийсэн.

-Тэгээд юу гэж?

-Зуу хүртлээ хуялынхаа хүчээр яваа юу?

-Ялдам минь! Миний өвөө наян хоёртойдоо гэрлээд, тэр авгайгаасаа гурван хүүтэй болсон. Тициан, ялдам минь, тахлаар үхсэн юм, тахал тусаагүй бол дахиад хэд наслах байсныг бүү мэд. Рафаэль тэгвэл? Тийм ээ, Рафаэль? Уран зурагт Рафаэлиэс дээгүүр хэн байна? Гэтэл гучин долоотой өөд болсон. Юунаас болсон бэ? Ажлаас уу? Үгүй шүү! Аугаа их зураачид бүгд амбан шар шиг ажилладаг байсан юм. Рафаэлийг салхинд цохиулснаас болж өнгөрсөн гэдэг боловч тэр бол худлаа! Рафаэль галзуу тачаалтай байсан, тэгээд Форноринагийнхаа өвөрт бэлгийн тамирдлаар үхсэн. Коровин бийрээ чулуудчихаад зуруулдаг хүүхэн рүүгээ дайрчихдаг байсан гэж байгаа. Бас Брюллов? Нөгөө Делакура байна, бүх насаараа ходоодны өвчтэй зовж гасласан язгууртан хүн, тэгсэн хэрнээ хүний, өөрийн нэг ч зуруулдаг хүүхнийг урдуураа гишгүүлж үзээгүй гэх.

Глеб хэдэн долоон иймэрхүү түүх мэднэ, түүнийгээ ярих дуртай, хүний мөнгөөр уух дуртай, ер нь харамч талдаа, гэхдээ түүнийгээ инээдэм ханиадам, тоглоом шоглоомоор хөөрхөн нуугаад байна. Санаа амар эр! хүнээс юм шалгаахгүй, хэнийг ч муу хэлэхгүй, Людагийн тухай юу хээ гадарладаг нь илт боловч ам нээнэ гэж гонж. Гэхдээ ам хамхихгүй бурна, худлаа зална, Сашаг сав л хийвэл мөрөөр нь тэвэрч авна. Харин ярих дургүй сэдвийг нь хөндвөл, жишээ нь улс төр, хоромхон зуур дуугүй болсноо тэр даруй яриаг өөр сэдэв рүү зувчуулж, дахиад л маазруулж, инээж, худлаа бурж гарна.

Глеб нэг удаа цаасаа ухаж байгаад Ленинградын яриан жүжгийн театрын зарлалыг Сашад үзүүлжээ. Тэр театрт Акимов бүр хориод онд “Криворыльскийкийн төгсгөл”, “Хуягт галт тэрэг 14-69”, “Тартюф” зэрэг жүжгийн зураг чимэглэлийг хийж байж.

-Акимовыг би Москвад л жүжиг найруулж байсан гэж боддог юм гэж Саша үнэнээ хэлэв.

-Нэг үе, хориод оны сүүлч, гучаад оны эхээр байсан, одоо түүнийг хэн болсон гээч? Ленинградын инээдмийн театрын уран сайхны удирдагч. Үзүүлж байгаа биз!

Ингээд бодохоор Глеб тэр болгон худлаа ярьдаггүй байх нь.

Тэрээр нэг удаа Сашаг аятайхан байшинтай танилындаа дагуулж очжээ. Замдаа хоёр охиныг нь магтаж гарах нь тэр:

-Дагинас! Намбыг нь ажаарай! Муужраад ойчмоор гэж мэд! Луугар шүү!

Гэвч Саша муужирч унасангүй.

Бүсэлхийгээ хүрсэн гээгтэй, нуман хөмсөгтэй, ухаалаг нүдтэй, цонхигор царайтай хоёр охин Глебийг үзээд баяр хөөр болсноо, Сашатай дотносог мэндлээд, сүүлчийнхээ олзыг үзүүлэхээр тэднийг өрөө рүүгээ дагуулж оров. Олз нь Булгаковын “Цагаан гварди” нийтлэгдсэн “Россия” сэтгүүлийн дугаар аж.

-Ялдамууд аа! Одоо цагт ийм юм олно гэдэг бол гайхамшиг! хэмээн Глеб дуу алдав.

-Та Москвагийн уран сайхны театрт “Турбиныхны өдөр хоног”-ийг үзсэн үү? гэж бага нь Сашагаас сонирхов.

-Үзсэн, гэхдээ би тэгэхэд арван тавгай байсан, Лариосикийн дүрд Яншин тоглосныг л санаж байна.

-Яншин цыган хүүхэнтэй гэж үнэн болов уу?

-Ёстой мэдэхгүй юм чинь тэр байна.

Хоолны өрөөнөөс дуудаж цай ууцгаа гэв.

Хоёр ахимаг авгай ширээний ард сууж байв. Ширээн дээр зочинд зориулж зэхсэн гарын ээвэн, элсэн чихэр пүргэсэн жимсний чанамал энэ тэр тавьж.

Дараа нь хөгжим сонсоцгоов. Хоёр бүсгүй төгөлдөр хуур руу зэрэгцэн суугаад, Чайковскийн “Дөрвөн цаг”-аас “Намар”-ыг тоглов. Бас Глебийн хүссэн ёсоор Шуберт, Шопеноос тоглолоо.

Глеб буцах замдаа баахан дуу алдав:

-Ямар вэ дээ! Дээд ангиллын сэхээтэн! Ийм хүмүүсийг өнөө үед хаанаас олох вэ? Гагцхүү Калинин хотноо л үлдсэн байгаа юм. Үнэндээ бол, даруухан амьдралтай, гэхдээ цайных нь хэрэглэлийг анзаараа биз дээ? Эзэн хааны шаазангийн завод!

Саша шаазангийн тухай мэдлэг маруухан учир айлынх нь тухайд “Аятайхан улс” хэмээн магтав. Үнэндээ бол, тэр хоёр бүсгүй сэтгэлийг нь даан ч хөдөлгөөгүй.

-Чи яагаад гэрлэдэггүй юм? гэж Тэрээр Глебээс асууна.

-Гэрлэх ий? хэмээн Глеб үнэн санаанаасаа гайхна. -Чи юу хэлнэ вэ, ялдам аа? Зураач хүн гэрлэх гэж үү?!

Бас нэг удаа тэр хоёр архи авч, Глеб өөр нэг танилындаа дагуулж очив. “Бичиг хэргийн бараа”-ны дэгүүрийн худалдагч гуч жаахан гарсан, сайхан зантай, наргиантай хоёр хүүхэн идээ, зуушаа дэлгэж. Архиа ууцгааж. Глеб ханан дээрээс туузтай гитарыг нь авч, “Хамаг юмаа ууна, баян хуураа л үлдээнэ, харин муусайн өлөгчинг албадан байж бүжиглүүлнэ...” гэж танхай аялаад утсыг нь хэд шудрав. Гэтэл тэр хоёр худалдагч, “Хулгайчийн дуу хэрэггүй” хэмээн шууд эсэргүүцэв.

-Хэрэггүй бол хэрэггүй л биз, өөр дуу дуулцгаая.

Эвийлж энхрийлэхийг эс ойшоон гомдоож,

Элэг доог хийсний учир юу сан бол?

Эргэх хорвоо дээр чамгүй бол

Эвлэх найзгүй болчих юм уу, би?..

Бал бурам, нил эрдэнэ шиг байсан ч,

Бадран дүрэлзэх гал сэтгэлд даанч авалцсангүй.

Алтан амтай чиний хэрэг надад үгүй

Аяа, гитар минь, аялгуулан, хүүрнэн дуул.

Төрөл саднаас минь дотно байлаа, чи

Төрсөн аав ээжээс минь үнэтэй байлаа, чи

Өст буруу элэгтэн шиг, чамайг

Өр зүрхнээсээ өмлөн хаяхаас яахав, би.

Бал бурам, нил эрдэнэ шиг байсан ч,

Бадран дүрэлзэх гал сэтгэлд даанч авалцсангүй.

Алтан амтай чиний хэрэг надад үгүй

Аяа, гитар минь, аялгуулан, хүүрнэн дуул.

Варя тэр хоёрын тухай дуулж байгаа мэт Саша Глебээс нүд салгалгүй ширтэнэ. Ээ, хөөрхий, ямар гунигтай хорвоо вэ, хэзээ ч ингэтлээ гуниглаж яваагүй сэн. Москвадаа харих юм сан, Арбатдаа очих юм сан, Варятай учирч тэврэх юм сан. Ээ, заяа нь орхи! Варягүй амьдарч чадахгүй юм байна, тэр муу бильярдчин ёстой падгүй, ер нь ямар хамаа байна. “Эвийлж энхрийлэхийг эс ойшоон гомдоож, элэг доог хийсний учир юусан бол...” Үнэхээр түүнийг гомдоосон бил үү? Гомдоож. Чухам тэр учраас ярианы эцэст дуу нь тийм урамгүй болчихсон

хэрэг.

Саша босч, баяртай гээд гарлаа. Глеб ч гарав.

-Чамтай ч ганзага нийлэхгүй юм шив гэчихээд Глеб чимээгүй арваад алхсанаа удаан уурлаж чаддаггүй учраас дахиад малилзаад ирэв. -Чи даяанч болох гээ юү? Үхсэн үлий нь хэрэгтэй юм бэ? Тийм үг сонссон уу?

-Сонссоон, сонссон.

-Гэхдээ ялдам минь, чи өнөөдөр их юм алдлаа шүү. Худалдагч энэ тэр нь ямар хамаа байхав, хүний аяар хүүхнүүд, оронд орсон хойно нэрэлхэж маяглахгүй, санасныхаа зоргоор эдлэж болно, хариуд нь баяр талархлын үг л сонсоно гэж мэд.

Тэр хоёр заримдаа хотын цэцэрлэгт очно. Хөгжим хангинаж, бүжгийн талбайн хайс хавиар “Пролетарка”, “Вагжановка” заводын охидууд шавааралдан байх. Өрнөдийн шинэ бүжигнүүд хөдөө дөнгөж тархаж эхлэж байгаа үе, харин Саша бол сайхан бүжиглэнэ.

Тэрээр охидын дундаас эвлэгхэн бүжиглэж буй нэг уяхан зэгзгэр охиныг сонгож урив. Тэр хоёрын хөл аятайхан нийлж, амьтан хүн ч анзаарав бололтой. Хөнгөн хөгжмийн ая Сашад Москва, “Арбатын нүх”, Варя энэ тэрийг санагдуулна. Варя одооных нь цуг бүжиглэж буй цайвар үстэй жирийн нэг охин шиг хөнгөхөн турьхан амьтан байж билээ.

-Ялдам минь, чи мундаг бүжиж байна шүү. Ёстой луугар! гэж Глеб уулгалав.

Найзынхаа хамт Сашаг харзнасхийн зогсож буй нөгөө охин руу Глеб дохиж,

-Тэр хоёрыг дөхүүлж өгөх үү гэж Сашад хэлэв.

-Болих уу даа.

-Олон ааш чинь хөдөлчихөж дээ, ялдам минь. За яахав! Явья, би чамайг Семен Григорьевичтэй танилцуулна.

-Юун хүн бэ?

-Манай ерөнхий бүжиг дэглэгч.

-Би тэрүүгээр чинь яах юм?

-Чамтай танилцъя гэсэн юм.

-Тэр надаар яах нь вэ?

-Ялдам аа, чи юу гээд “яах юм, яах юм” гээд байна вэ? Чиний бүжиглэж байгаа чинь аятайхан санагдахгүй юү.

-Би түүгээр үлийгээ хийхэв дээ?

-Ялдам минь, тэр чинь миний дарга.

-Яахаараа тэр билээ?

-Баруун европын бүжиг заадаг юм, би аяыг нь дарж өгнө.

-Тэгвэл очье.

Тэр хоёр бүжгийн талбай дундуур чигээрээ явж, урт сандал дээр сууж байгаа долгионт хар үсээ толийтол самнасан, хар костюмтай, цагаан цамцтай, эрвээхэй зангиатай тавь эргэм насны биерхүү хүн рүү очив. Өрөөсөн гартаа таяг тулчихаж. Сашатай мэндлэхдээ яльгүй өндөсхийв. Нийслэлийн их урлагийн хүн гэлтэй дэгжин, толиотой эр аж.

-Танд магтаалын үг дуулгая, та гаргууд сайхан бүжиглэж байна. Та энд тэнд сургууль хийж байсан уу?

-Үгүй ээ, хаа ч сургууль хийж байгаагүй.

-Таны гишгэдэл хэм сайтай, бас бүсгүйгээ тун итгэлтэй залж байна.

Саша инээмсэглэн,

-Байж байгаа царай нь л тэр гэв.

-Та манай хичээлд оч л доо, Глеб, та нөхрөө дагуулаад ирэхгүй юү хэмээн Семен Григорьевич урив.

-Дагуулаад ирье ээ гэж Глеб амлав.

За тэгэхээр, “Фермчин” хочтой, ЕЖ-13 дугаартай тагнуулч бол Парист төвтэй ОНЦХ-ны нэг удирдагч, генерал Николай Владимирович Скоблин гэгч байх нь. “Фермчиний авгай” хочтой тагнуулч нь Скоблины эхнэр, алдарт дуучин Надежда Васильевна Плевицкая.

Шарок хавгаст хэргийг хэд дахин уншив.

Николай Владимирович Скоблин 1893 оны зургадугаар сарын 9-нд Нежин хотноо огцорсон хурандаагийн гэр бүлд төржээ. 1914 онд Чугуевын цэргийн дунд сургууль төгсөөд, байлдаж байгаа армид, Рыльский 126 дугаар хороонд томилогдсон аж. Герман, австричуудтай хийсэн тулалдаанд онцгойрч байж. Октябрийн хувьсгалын дараа Корниловын хорооны дарга, залуухан ахмад Скоблин Ар Кавказад улаантнуудтай тулалдаж байгаад, 1919 оны тавдугаар сард Корниловын дивиз командлагчаар томилогдож, Май-Маевскийн Сайн дурын армийн бүрдэлдэхүүнд Москваг дайрах аян дайнд оролцжээ.

Надежда Васильевна Плевицкая 1884 оны нэгдүгээр сарын 17-нд Курск мужийн Винниково тосгонд тариачин Василий Абрамович Винниковын гэр бүлд төржээ. Арван нэгдэх хүүхэд нь. Үнэнхүү сүсэгт эх нь түүнийг Курск хотын Троицкийн охидын сүмд шавилан суулгажээ. Тэр сүмээс оргож, нүүдлийн циркт очсон, цэнгээний газар найрал дуучин болсон, дараа нь бүжгийн багт шилжиж, бүжгийн жүжигчин Эдмунд Вячеславович Плевицкийтэй сууж, Винникова байснаа Плевицкая болжээ. Яваандаа орос ардын гарамгай дуучдын нэг болж, Орос нутгаар айлчлан тоглож, хаанд хүртэл ая дуугаа өргөж явжээ. Хувьсгалын дараа 1918 оны зун Улаан Армийн ангиудаар нүүдэллэн дуулж, сонин хэвлэлээр “ажилчин-тариачны дуучин” гэгдэх болж явсаар Одесст очжээ. Улааныхныг Одессоос ухрах үед есдүгээр сарын 4-нд Софроновка тосгонд корниловчуудад олзлогдсон.

Плевицкаягийн тухай материалд дэлхийн болон иргэний дайны үе тэр чигээрээ тодорхой бус байгааг Шарок анзаарав. Хэдэн эрэгтэй хүний нэр цухас гарч байна: шинэ сүйт хархүү ахмад Шангин, большевик Шульга, хоёрдахь нөхөр штабын ахмад Юрий Левицкий, Корниловын хоёрдугаар хорооны дарга, хурандаа Пашкевич... Ганцхан тодорхой огноо байна: 1921 оны есдүгээр сар, Турк, Галлиполи-хорин найман настай генерал Скоблинтэй хуримлажээ.

Скоблин, Плевицкая хоёр Галлиполиос Болгар руу явжээ. Тэнд генерал Врангель 1924 оны есдүгээр сарын 1-нд цагаан армийг Оросын нийт цэргийн холбоо болгон өөрчлөн байгуулсан тухай зарласан байна. Скоблин корниловчуудын командлагчийн албандаа, генерал цолтой хэвээр үлджээ. Дараа нь дахиад бүдэг бадаг зүйл: Болгарын дараа Балт орчмын улсууд, Польш, Чехословакаар айлчлан тоглож, эцэст нь Берлинд очсон. Берлинээс хойш мэдээ нь илүү ончтой, илүү тодорхой болж байна. Скоблиныхон Берлинд баян худалдаачин Марк Яковлевич Эйтингонтой ойртож байна. Тэр нь одоогийн ДЯАК-ын генерал Наум Эйтингоны ах. Плевицкая дуучны хувьд хилийн чанадад гайхам түргэн алдаршчээ. Скоблин тэр хоёр дэлхийг тойрч байна: Брюссель, Белград, Америк, эцэст нь Франц, тэндээ суурьшжээ. 1926 онд Америкт дахин ялгуусан тог-лолт хийсэн, 1927 оны тавдугаар сард Парист буцаж ирсэн. 1928 онд ОНЦХ-ны Ерөнхий командлагч генерал Кутепов Скоблиныг ОНЦХ-нд идэвхтэй үйл ажиллагаанд татан оруулжээ.

Хавтаст хэрэгт Скоблины 1930 онд ЗСБНХУ-ын ТГХ-нд бичсэн, түүнд ганцаарчлан өршөөл үзүүлж зөвлөлтийн иргэн болгож соёр-хохыг хүссэн өргөдөл байна. Дараачийн хуудсанд нь ЗСБНХУ-ын ТГХ-ны Скоблин, Плевицкая хоёрт тухайлан өршөөл үзүүлэх тухай Тогтоол байна. Бас ЕЖ-13 дугаарын тагнуулчид сар бүр хоёр зуун доллар төлж байх заалт байна. Энэ шийдвэр генерал Кутеповыг хулгайлсны дараахан гарсан байх боловч, энэ үйлдэлд Скоблин оролцсон тухайд шууд холбогдох материал Шарок олж үзсэнгүй.

Скоблины цагаачдын ажил явуулгын тухай (эвдэн бусниулагчдыг бэлтгэж явуулах, тагнуулч элсүүлж авах гэх мэт) тогтмол мэдээлэхээс гадна ОНЦХ-ны удирдлагад орох гэсэн тэмцлийн тухай тодорхой илтгэж байжээ. Тэр тэмцлийн дүнд Скоблин 1935 оны дөрөвдүгээр сард ОНЦХ-ны “дотоод чиглэлийн” удирдагчаар, өөрөөр хэлбэл, уг холбооны Онцгой комисс буюу Улс төрийн ерөнхий газрын удирдагчаар томилогджээ. “Дотоод чиглэл” нь ДЯАК-ын туршуул ОНЦХ-нд, цаашилбал, цагаач цагаантнуудын дунд нэвтрэхийн эсрэг тэмцэх зорилготой. Скоблиныг ийнхүү томилогдсоноор ДЯАК-ын зүгээс тэдний дунд ажил явуулахад хялбар болжээ.

Энэ хоёрыг юугаар өөшилчихсэн юм бол? гэж Шарок бодов. Сарын хоёр зуун доллараар уу? Арай ч дээ. Оросын цагаачид Плевицкаяд их дуртай. Сая сая цагаачин байгаа учраас Тэрээр орлого сайтай. Ц а г а н т н ы үзэл санаанд урам хугарч у л а а н- т н ы х а д итгэх болоо юу? Цэргийн дээд боловсролгүй мөртлөө хорин зургаахан насандаа дивиз командалж эхэлсэн, гавьяа зүтгэлтэй, идэр дайчин генерал у л а а н т н ы үзэл санаагаар яах юм бэ? Өөртөө эрэмшсэн авьяаслаг жанжин, гэхдээ Москвад очоод дээшээ хол явахгүйгээ сайн ойлгож байгаа. Харин Плевицкаягийн сэдлэг илүү тодорхой байна: Нөхөр нь сайхан эр, түүндээ сэтгэлийн жолоо алдсан, нөгөөтэйгүүр олон эгч учраас нөхөр хаашаа вэ, тэр тийшээ. Нэмэрт нь хилийн чанадад дуулснаас эх орондоо дуулсан нь илүү ирээдүйтэй гэдэгт итгэж байгаа.

Гэтэл Скоблин ямар учиртай ингэв?! Долоон жилийн өмнө өршөөл үзүүлж, харьяатыг нь сэргээн тогтоосон боловч тэр хоёрын алиныг ч Зөвлөлт рүү оруулахгүй, тэнд нь бариад байна. Ер нь ч ЗХУ-д түүнд хийх юм байхгүй юм чинь, тэнд нь зөндөөн удаан барина. Тэгэхээр нартад хоногийн тоогоо гүйцтэл өөрсдийгөө ийм дөнгөнд оруулсан байх нь. Хэрвээ хэрэг нь илэрвэл наад зах нь олон жилийн хоригдох ял авна.

Сүүлийн жилүүдийн цагаачдын сонинд тэр хоёрыг хардсан зүйл нэг бус удаа гарсан. Харин Скоблин ямар ч эгзэгтэй байдлаас овжин гарсаар өдийг хүрчээ. Гэхдээ л хардлага, сэрдлэгт нэгэнт орсон болохоор Скоблин, Плевицкая хоёр хэр удаан тэсдэг бол?

Нөгөөтэйгүүр Слуцкий, Шпигельглас хоёр яагаад чухамхүү одоо тэднийг гойд сонирхох болов? ОНЦХ-нд гэхэд л Скоблин шиг дээгүүр албатай биш ч, түүнээс дутуугүй мэдээлэлтэй туршуулууд бий. ДЯАК-ын хамаг хүч, анхаарал Радек-Пятаковыг шүүх, Бухарин-Рыковын хэргийг шүүх ажиллагааны бэлтгэлийг хангах асуудал дээр төвлөрчихөөд байхад, Ежов юуны учир Скоблиныг онцгойлон үзэж байна?

Хоёрдугаар сард ДЯАК-ын аппарат нэгэн санамсаргүй мэдээнээс ихэд цочирдов. Зиновьев-Каменев, Пятаков-Радекийн хэргийг шүүх ажиллагааг бэлтгэсэн гол хүн, улс төрийн нууц хэлтсийн дарга Молчанов баривчлагджээ. Гуравдугаар сарын эхээр онцгой хэлтсийн дарга Гай, түүний орлогч Воловик, тээврийн хэлтсийн дарга Шанин, аппаратын бас бус хэдэн

хүнийг баривчилжээ.

Ежов гуравдугаар сарын 21-23-нд Лубянка дахь ДЯАК-ын клубт Улсын аюулаас хамгаалах ерөнхий газрын идэвхтнүүдийн зөвлөлгөөн хийлгэв. Ардын комиссар мундаг ширүүн үг хэлжээ. Тэрээр троцкийч-зиновьевч-бухаринч зулбасагануудыг хараан зүхсэн төдийгүй, Ягода, Молчанов зэрэг харьяа ажилтнууддаа “хийгүй” мөрдөхийг сургаж байсан хүний шаарнуудыг бут ниргэв. Баримтаас үзвэл, Ягода мөрдүүлэгчдийг хэргээс мултлахыг оролдож, тэднийг байцаасан протокол дээр, “балай юм”, “юу ч биш”, “шал худлаа”, “буруу” гэхчилэн цохож байж.

Ежовын дараа түүний нэгдүгээр орлогч Агранов үг хэлж, Ягода, Молчанов хоёрыг мөн зад шүүмжлэв: -Ягода, Молчанов хоёр намын эсрэг, буруу чиг шугам баримталж ирсэн... Молчанов мөрдлөгийг саатуулах гэж зориуд оролдож байсан... Нөхөр Сталин мөрдлөгийн алдааг зааж өгч, хөндлөнгөөс оролцоогүй бол троцкич зандалчдыг устгах ажил тасрах байсан... Сталин троцкийст төвийг илчлэх, нуугдмал буй алан хядагчдын бүлгийг, түүнчлэн Троцкийн биечлэн гүйцэтгэж буй үүргийг нээж илрүүлэхийг даалгасан... Чухамхүү Сталины эдгээр заалтыг үндэс болгосноор троцкийч-зиновьевч төвийг нээн илчлэх боломжтой болсон...

Аграновын дуу гудиггүй цангинаж байгаа ч, авгай нь энэ бай-шингийн шоронд хэдэн сар болж байгааг ажилтан нараас мэдэхгүй хүн үгүй билээ. Тэрээр Ягодаг муулж, Сталиныг шагшин магтах замаар хоёрдугаар давхрын албаны тансаг өрөөндөө цаашид ч сууж үлдэнэ гэж горьдсон биз.

Гэвч хурлын дараа түүнийг баривчилжээ.

Ягодын нарийн бичгийн дарга Буланов, украины ДЯАК-ын дарга Кацнельсон нарыг баривчилсан бол Горький хотын ДЯАК-ын дарга өөрийгөө буудан хорложээ. Дөрөвдүгээр сарын 3-нд Ягодаг, төдөлгүй түүний орлогч асан Прокофьев, Артузов, Балицкий, Дерибас, Фирин болон ДЯАК-ын хэтэрхий олон юм мэддэг өдий төдий ажилтныг баривчилж, оронд нь цоо шинэ хүмүүсийг аппаратаас буюу орон нутгаас дэвшүүлэн томилжээ. Ежов ДЯАК-д гэнэт “чекистийн хуйвалдаан” илрүүлж, шийдвэртэй арга хэмжээ авч устгасан нь тэр.

Молчановын толгойлж байсан улс төрийн нууц хэлтэс, ялангуяа Шарокийн хуучин байсан нэгдүгээр тасаг бусдаас их нэрвэгджээ. Вутковский баригдаж, түүний орлогч Штейн өөрийгөө буудан амиа хорложээ. Дэслэгч цолтой Виктор Семенович Абакумов тэр үеэр дэвшив. Энэ Абакумовыг ноднин Хорихыг удирдах газрын системээс техникийн бусад ажилтны хамт хэрэг үдэгчээр авсан юм байж. Нөгөө хавтастай ноцолдож, хэрэг үдэж байсан хүн чинь улс төрийн нууц хэлтсийн ажилтан байсан хүмүүсийг одоо байцаадаг болох нь тэр. Соёлгүй, хэрцгий нэгэн. Шарок өөрөө ч гэсэн түүнд байцаагдаж мэдэх байсан гэж бодохоос үстэй толгой нь арзасхийнэ. Яг түүний ивээл дор ажиллаж байснаа Абакумов юман чинээ бодохгүй дээ. Абакумовыг боловсрол багатай, овсгоогүй молхи хэмээн Вутковский буцааж явуулах гэхэд Шарок түүнийг өрөвдөн хаа-цайлж авч үлдсэн төдийгүй, юуг яаж хийдгийг биечлэн зааж, хоёр долоо хоног хамт ажиллахдаа бараг найзлах болжээ. Абакумов Шарокийн ачаар үлдсэнээ ойлгосон учир түүнд талархан, үнэнч нохойн харцаар түүнийг ширтдэг байж. Гэвч мань хүн түүнд байцаагдаж таарах юм бол нөгөө талархлын сэтгэл ууршин арилж,

бүтэн мөч үлдээхгүй тээрэмдэх байсан даа.

Гадаад хэлтэст шилжсэн нь ямар аз вэ. Ежов одоохондоо гадаад хэлтсийг хөндсөнгүй. Тэндхийн ажилтнуудыг солих хүн байхгүй, хилийн чанад дахь ажлаа унагаж болохгүй. Гэхдээ энэ хэлтэст олон юм мэдэх хүн дэндүү элбэг, Ежовын гар эрт, орой алин боловч ийшээ хүрэхдээ л нэг хүрнэ.

Шпигельглас ч үүнийг ойлгож байж. “Тэрч нарыг” толгой дараалан устгах ажил явж байна, мань хүн түүний нэг нь гарцаагүй мөн. Тийм учраас Ежов Шарокийг түүнд биечлэн “хадсаныг” санамсаргүй зүйл биш хэмээн үзэж, Шарокоос, түүний санаандгүй нэг үгнээс өөрийнх нь хувь заяа шалтгаалж болохыг үгүйсгэхгүй байв. Эдний байгууллагад хувь заяа гэдэг бол амьдрал, үхэл хоёрын нэг билээ.

Гэвч өнгөн дээрээ тэдний харьцаанд өөрчлөлт гарсангүй. Тэрээр Шарокт царай өгье гэж мэрийсэнгүй, үл тоомсорлох байдал ч юу гэж гаргах вэ.

Яг явахын өмнөхөн, дөрөвдүгээр сарын сүүлчээр тэр хоёр Шарокийн өмсгөлийн тухай дахин ярилцав.

-Надад хоёр гайгүй зангиа бий, би танд авчирч өгөмц. Таны костюманд илүү зохино гэж бодож байна. Бас нэг багц шинэ нусны алчуур бий. Гэрийн шаахай очингуутаа авна... гэж Шпигельглас хэлэв.

Парисын аялал тэр хоёрыг ойртуулжээ. Шарок Экспортлес (Модны экспорт)-ийн ажилтан Шаровский гэгч болж, Шпигельглас бас өөр нэрээр явцгаав.

Тэр хоёр олон улсын вагонд хоюулхнаа нэг тасалгаанд тасалбар авчээ. Ажил дээр үг цөөтэй, хүйтэндүү царайтай Шпигельглас замд цуг явахад урамтай хань болж таарав. Тэр хоёр вагоны өрөөнд өөд өөдөөсөө харж суугаад, галт тэрэг хөдөлмөгц Шпигельглас гэнэтхэн инээвхийлж,

-Та галт тэргээр явах дуртай юу? гэв.

Шарок дал мөрөө хавчисхийв:

-Ийм вагонд бол, мэдээж, сайхан л юм... Гэхдээ галт тэргээр бараг явж байгаагүй. Ихэнхдээ Москвагийн хаяа руу явж байснаас цаашгүй.

-Би бол дуртай, цонхоор харж явах дуртай гээд Тэрээр хөшгийг хоёр тийш нь ярав. -Манай энэ уудам цэлгэр нутгийн бараа, энэ ой төгөл, энэ талбайд дуртай. Орос нутгийн нэгэн янзын байгалийг харахаар сэтгэл уужирдаг юм. Ажлынхаа тухай, юу хийх гэж яваагаа би үргэлжлүүлэн бодно, гэхдээ сайхан тайван, бүхнийг огоорсон мэт бодно. Үүнийг анхааралдаа авахыг зөвлөө. Европоор явахын цагт ийм юм алга болно. Тэнд бүх юмыг базчихсан мэт хий жирэлзээд, нүд тогтоож харах юу ч байхгүй.

Хаалга тогшлоо.

Шпигельглас босч онгойлгов.

Үйлчлэгч суурь бүхий шилэн аягатай цай, жигнэмэг авчирч, цагаан хэрэглэлийн үнэ төлөхийг хүсэв.

Мөнгөө өгчихөөд, Шпигельглас аяныхаа цүнхнээс нэг шил ликер дарс гаргаж онгойлгоод, Шарокоос,

-Та цайндаа хийх үү, жүнзээр уух уу? гэж асуув.

-Жүнзээр.

Шпигельглас цүнхнээсээ нэг нэгэндээ ордог төмөр хундага гаргаж, нэгийг нь Шарокийн өмнө тавьж хундгалаад, өөртөө цай руугаа хийлээ.

-Би элсэн чихэр, ёотон хэрэглэдэггүй, удамшлын шижингээс бол-гоомжилдог юм, цай, кофе аль нь ч бай ликертой юм уу, коньяктай ууна. За, аян замын дөрөө өлзийтэй байх болтугай!

Шпигельглас жигнэмэг эмтлэн, цайгаа зугуухан уух зуур,

-Юрий Денисович, та бид хоёр ноцтой үүрэг гүйцэтгэхээр явж байна, нөхцөл байдал төвөгтэй байх болно, та үүнийг маш сайн ойлгож байгаа... Бид хоёр биенээ түшиж тулж явах ёстой, нэг нэгнийгээ аврах ч хэрэг гарч магадгүй. Тийм учраас бие биендээ гарцаагүй итгэлтэй байх ёстой. Тийм биз дээ? гэж ярив.

-Тэгэлгүй яахав.

-Бидний хооронд үл ойлголцсон, хагас дутуу таамагласан зүйл байж болохгүй. Бид хоёр тус тусдаа гадаад паспорттой, гэхдээ нарийн яривал, нэг л хүн гэсэн үг, намынхаа даалгаврыг биелүүлж яваа нэг хүн. Тэгэхээр бие биендээ гарцаагүй итгэхгүйгээр бид энэ үүргээ биелүүлж чадахгүйд хүрнэ.

-Яриангүй.

Шпигельглас цайндаа ликер нэмж, халбагаар хутгав.

-За, тэгвэл, би танай сургуулийн франц хэлний багшийг мэдэж байсанд та гайхсан, тийм биз дээ?

-Юу гэмээр юм бэ дээ? Энэ тухай нэг их бодоогүй шүү.

Шпигельглас түүн рүү гайхасхийн харав.

-Бодоогүй гэж үү?

-Намайг гадаад хэлтэст томилохын өмнө нарийн шалгаж, гадаад хэл хэнээр заалгасныг сонирхсон байж болно гэж үзсэн учраас “бодоогүй” гэж байгаа юм хэмээн Шарок зувчуулах

гэж оролдов.

Шпигельглас итгэхгүй буй нь илт түүнийг сонжин харав.

-Тэр тийм биш ээ. Өрнөдөд нэг томоохон профессор, утга зохиолын нэртэй шүүмжлэгч аж төрдөг юм. Зөвлөлт засаг түүнийг хилийн чанад руу хөөсөн хэрэг. Тэгэхээр цагаачин, уул нь кадетийн үзэл бодолтой, зөвлөлтийг яснаасаа үзэн ядагч. Харин хүү, охин хоёр нь Оростоо үлдсэн юм. Хүү нь коммунист, тодруулж хэлбэл, коммунист байж байгаад бухаринтны барууны бүлэгт орж одоо баригдсан, охин нь таны сурч байсан сургуульд франц хэл заадаг юм. Энэ учраас би түүнийг мэдэж байгаа юм. Толгой эргэхээр юм алга байгаа биз. Гэхдээ намайг ийм юм мэдэж байгаад та эгдүүцсэн байх, тийм үү?

-Тэр ч тийм шүү. Аюулаас хамгаалах байгууллагад гурван жил өөгүй ажилласан хүнд итгэх болов уу гэж бодсон юм.

-Тэр тухайд таны зөв. Таныг хэн ч зориудаар шалгаагүй. Энэ зүйл ингээд тодорхой болсонд баяртай байна. Бидний харилцаанд өөр тодорхой бус зүйл танд байна уу?

-Байхгүй, таны тухайд надад ямар ч гомдол санал байхгүй гэж Шарок хариулав.

Тэрээр үүнийг чин санаанаасаа хэлсэн боловч, Шпигельглас энэ тухай эхний уулзалтаар хэлдэггүй юм гэхэд, хоёрдахь уулзалтын үед, мань хүн сургууль, Ирина Юльевнагийн тухай сануулж байхад хэлж болох л байсан гэж бодов. Тэгэхэд хэлээгүй хэрнээ, өөртөө ашигтай гэж үзээд одоо хэлж байна. Нохойтож байх нь.

-Тэгвэл ажлынхаа асуудалд оръё гэж Шпигельглас хэлэв. -“Фермчидийн” хэрэгтэй танилцах явцанд танд ямар асуулт гарч байв даа?

Шарок хоёр зүйлийг сонирхож байв: “Фермчидийг” ямар аргаар элсүүлж авсан, тэд юуны учир манай талд ажиллаж байна? Одоо ямар тодорхой зорилгоор тэд хэрэгтэй болсон юм?

Гэхдээ эхнийх нь зохистой асуулт биш, хариулахын тулд тэднийг элсүүлсэн хүн энэ тэрийн нэрийг хэлэх хэрэгтэй болно. Шпигельглас тэдний явж буй зорилгыг өөрөө тайлбарлаж өгөх учраас хоёрдугаар асуултыг тавихгүй байж болно.

Иймийн учир Шарок гуравдахь асуултаа тавив.

-Би тэдний хавтаст хэргийг хэд дахин анхааралтай уншсан. Гэтэл тэдний нэг ч тодорхойлолтыг олж үзсэнгүй. хүний хувьд ямар хүмүүс вэ? Сул тал нь... Янз бүрийн нөхцөлд ямар товчлууур дээр нь дарвал зүгээр бол?

Шпигельглас нэлээн азнаж байж хариулав.

-Туршуулын сэтгэл зүй, хөдлөх сэдлэг энэ тэр, мэдээж маш чухал. түүний мэдсэнээр үйлдлийг нь урьдаас таамаглах, боломжийг нь үнэлэх бололцоотой болно. Гэхдээ энэ үнэлгээ бол, ёс шиг хувь хүний үнэлгээ байдаг юм. Би өөрийнхөө санал бодлыг танд хэлж болох, гэвч хэрэггүй гэж бодож байна, бас л миний хувийн бодол юм чинь, та өөрөө

үнэлгээгээ тогтоох боломж гарна. Гол асуудал бол тэд хэр зэрэг найдвартай вэ гэдэг байгаа юм. “Фермчин” бол найдвартай туршуул. түүнийг ОНЦХ-ны даалгавраар бидэнтэй хамтарч ажиллаж байна гэж үзэж болох уу? Үгүй гэж бодож байна. Цагаачдын дотор бөөн хов жив, хэрүүл уруул байдаг учраас ийм юм илэрвэл аюултай, нэр төрөө нэгмөсөн алдаж мэднэ. Ямар ч атугай, энэ чиглэлд сэжиглэх ямар ч баримт байхгүй. Харин түүний германчуудтай холбоотой нь баттай тогтоогдсон. Өөрөө ч үгүйсгэхгүй байгаа. Тэгээд бид тэр холбоог нь ашиглаж байгаа юм. мань хүн ОНЦХ-ны ихэнх, ялангуяа өөрийнх нь түшиглэдэг залуучууд Германыг ЗСБНХУ-ын гол сөргөлдөгч гэж үзэж, түүгээр баримжаалах чиглэлтэй байдаг учраас өөрөө Германтай холбоотой болсон гэж тухайн үедээ тайлбарласан юм. “Фермчин” ОНЦХ-ны доторхи байдлын тухай германыханд мэдээлэл өгч байгаа нь мэдээж. Тэрээр бидэнд ОНЦХ-ны доторхи манай дайсны тухай мэдээлдэг бол германы талд уг холбоон дахь тэдний анд нөхдийн тухай мэдээлж байгаа. Товчоор хэлбэл, ОНЦХ-ны удирдлагыг гартаа авах санаатай өөрийнхөө тоглоомыг тоглож байгаа бөгөөд өрсөлдөгч нараа бидний туслалцаатай зайлуулж байгаа юм. Бидэнтэй холбоотойг нь германыхан бас мэднэ, гэхдээ мань хүн энэ холбоогоо Германы талд ашигтай байдлаар танилцуулдаг юм.

Шпигельглас чимээгүй болж, цайгаа гүйцээж уугаад, цонхоор харж хэсэг суув. Тэгснээ,

-Энэ хосын хэн нь толгойлогч вэ? гэж дахин яриагаа эхлэв. -Энэ тухайд янз янзын санаа бий. Плевицкаяг эзэрхий хүүхэн гэх яриа бий. “Фермчин”-г цагаачдын дотор бүр “генерал Плевицкий” гэж нэрлэх нь бий. Гэхдээ бидний хувьд, бидний энэ удаагийн зорилгын хувьд “Фермчин” л чухал, гагцхүү тэр.

Шарок түүнийг чих тавин сонсов. Шпигельгласын ярьж буй зүйл бүгд үнэн, гэхдээ гүйцэд биш. Тэрээр Эйтингоныг нэг ч удаа дурдсангүй, уул нь тэр хүн Скоблин, Плевицкая хоёртой нөхөрлөдөг нь санамсаргүй зүйл биш нь мэдээж. Гэтэл Шпигельглас энэ тухай дуугарахгүй, энэ холбоог дурдахыг хүсэхгүй байна. Болгоомжтой буй нь тэр... Гэхдээ түүнийг сонсох л хэрэгтэй. Скоблин яг одоо юуны учир хэрэгтэйг Шпигельглас хэлэх ёстой. Энэ бол гол зүйл.

-Бидний зорилтын тухайд хэмээн Шпигельглас дуу нь дахин тодроод ирэв. -Та дивиз командлагч Шмидт, корпус командлагч Путна, Примаков гурав баригдсан тухай, мэдээж, мэдэж байгаа, тийм үү?

-Тийм ээ, мэдэлгүй яахав.

-Радекаас маршал Тухачевскийтэй ямар холбоотойг асуухад тун бүдэгхэн юм хариулдаг, та, бодвол, санаж байгаа байх?

-Тийм ээ, би анзаарсан. Дэндүү ширүүлсэн учраас үнэмшил муутай байсан.

Хэрэг явдал хаашаа хэлбийж буйг Шарок гадарлаж эхлэв.

-Маршал Тухачевский, тэргүүн зэргийн армийн комиссар Гамарник, тэргүүн зэргийн арми командлагч Якир, Уборевич, дэд зэргийн арми командлагч Корк, корпус командлагч Примаков, Путна, Эйдеман, Фельдман нар Германы рейхсверийн командлалтай сүлбэлдэж, тэдний төлөө тагнуул хийж, цэргийн эргэлт хийхээр бэлтгэж байгаа, нөхөр Сталиныг болон

нам, засгийн бусад удирдагчийг алах санаатай байгаа тухай няцаагдашгүй баримтууд намын Төв Хороонд, нөхөр Сталинд бий.

Шарок ийм мэдээ сонсоод гайхсангүй. Тэрээр ДЯАК-д гурван жил ажиллахдаа юунд ч гайхдаггүй болж сурчээ. Нэг шүүн таслах ажиллагааг бэлтгэх явцад Молотовын тухай хүртэл баримт цуглуулж байсан юм чинь. Ардын дайсан, алуурчид, тагнуулчдыг нөхөр Сталин нэрлэнэ, тэдний бурууг нотлох нь ДЯАК-ын ажилтнуудын үүрэг. Эдүгээ цэргийн удирдлагууд ардын дайсан болох ээлж иржээ.

-“Фермчин” дурдсан хүмүүсийг илчлэх материалыг Берлинээс олох ёстой. Тэгээд түүнийгээ бидэнд гардуулж өгөх юм.

Тэгээд хэсэг чимээгүй болсноо,

-Хариуд нь “Фермчин”-д албан тушаал ахихад нь туслахаар амласан байгаа.

“Албан тушаал ахих” гэдэг нь ОНЦХ-нд оо гэсэн үг.

-Зорилт ойлгомжтой хэмээн Шарок толгой дохив.

Биеэ барих хэрэгтэй. Софья Александровна дээр ингэж удаан очоогүй маань тусгүй хэрэг, түүнийг орхивол хүнлэг биш, хуншгүй, өширхсөн явдал болно. түүнийг буруушаагаад яхав, ам алдвал барьж болох биш. Өөрөө ч гэсэн сэтгэлийн зовлон эдлэж, Костягийн тухай Сашад ярьсандаа шаналж гүйцэж байгаа. Сашаг авгайтай байсан гэж Варя мэдлээ гэхэд, байсан юм байгаа л биз гээд тоох ч үгүй. Гэтэл Саша ийм явдлыг тэс өөрөөр тусгаж авч. Хэрвээ өөрт нь хайртай байсан бол Костягийн тухай сонсоод балартаж, урван тэрсэлсэн явдал хэмээн өршөөж чадахгүй байх нь. Хэрвээ хайргүй байсан бол цөлөгдөж түмэн зовлон эдлэж яваа хүнд түүний мөрийчин нөхөр шүү юмны тухай сонсох, энэ эрүүгийн хэрэг ханхалсан явдлыг мэдэх ямар ч сонирхол байхгүй, харин ч шал дургүй нь хүрээд, Калинин руу очих тухай саналыг нь хүлээж аваагүй байх. Ийм байж болохыг Варя үгүйсгэхгүй байлаа.

-За, би хүрээд ирлээ, ажлаа дуусаад шууд тань руу ирлээ гэж Варя босго алхав уу, үгүй юү дуржигнуулав.

-Варюшенька, хонгор охин минь хэмээн Софья Александровна үнэнхүү баярлан өгүүлэхэд Варягийн зүрх базлаад ирэх шиг болов.

-Яаж шуу аж төрж байна даа, яриад байна шүү.

-Хоног төөрүүлсэн шүү л байна, Варенька минь. Чи ажлаасаа явна уу?

-Тийм, юу гэж?

-Ганц таваг мөөгтэй шөл өгөх үү л гэж.

-Болно шүү.

Арав хоногийн дараах анхны уулзалт хэвийн өнгөрөв. Софья Александровна шарх сорви сэдэрээхгүйн тулд Сашагийн тухай дурссангүй.

-Маргааш ирэх үү?

-Заавал ирнэ.

Михаил Юрьевич дандаа эзгүй таараад, Варя түүнтэй ойрд уулзаагүй билээ. Зүгээр ч үгүй, тоглоомоор, “Манай Михаил Юрьевич айлд хүргэн ороо юм уу?” гэж асуусан удаатай.

-Заримдаа бүр үүрээр ирэхийг нь яана, бид хаалганыхаа гинжийг хийхээ больсон хэмээн Софья Александровна инээмсэглэв. -Гэхдээ чиний урмыг хугалах нь. хүн амын тооллоготой холбогдсон толгой өөд татахын аргагүй ажилтай болоод л тэр.

Өө, тийм шүү дээ, нэгдүгээр сард бүх холбоотын хүн амын тооллого болсныг мань хүүхэн таг мартчихсан аж.

Эцсийн бүлэгт Варя түүнтэй байрных нь хонгилд тааралдаж, санаж үгүйлснээ хэлээд,

-За, тэгээд, Михаил Юрьевич, бүх хүнээ тоолов уу, хэнийг ч мартаагүй биз дээ гэж асуув.

-Тэгэлгүй яахав, Варенька, бүх хүнээ тоолсон, байгааг нь бүгдийг тоолсон. Байхгүйг нь, мэдээж, яаж тоолох вэ дээ.

Хачин юм ярьдаг хүн шүү.

-Манайд орж цай ууцгаая гэж Михаил Юрьевич урив.

-За, тэгье, юун сайн юм бэ.

Варя суух дуртай цөмөрхий буйдан сандал дээрээ гарч тухлав.

-Манайд бас ирсэн, зугаатай юм билээ хэмээн Варя сониноо хуучлав. -Бурханд сүсэглэдэг үү? гэж надаас асуусан. “Тийм ээ, сүсэглэдэг гэж хариуллаа. Тоолж яваа залуу хоёр нүд нь орой дээрээ гарчихаад, “Та үнэнээсээ хэлж байна уу?” гэж байна. “Үнэнээсээ байлгүй яахав. Та бурханд сүсэглэдэггүй юм уу?” гээд хэлчихлээ. “Би сүсэглэдэггүй, үгүй”. -“Тэгвэл таны ээж?” Нөгөө залуу юу ч хэлэлгүй хөмсөг зангидсанаа, миний хүснэгтэд “Сүсэглэдэг” гэж бичсэн. Бодвол, би түүний тооллогын үзүүлэлтийг сэвгүүлсэн байх, уул нь тэдний санаагаар бол үлдсэн хэдэн сүм хийдийг нурааж хаяхын тулд бүх нийтээрээ сүсэг бишрэлгүй гэсэн дүн гараасай гэж хүсч байгаа л даа.

-Тэнэг асуулт, хүн амын тооллогын асуултад хэзээ ч орж байгаагүй зүйл гэж Михаил Юрьевич өгүүлэв.

-Хүмүүс үнэнээ хэлэхээс айгаад шашин шүтдэггүй гээд байна. Одоо чинь “Тийм ээ, би Бурханд сүсэглэдэг” гэж хэлж чадвал жирийн хүний хувьд гавьяа байгуулсантай адил болчихож шүү дээ. Минийх бол гавьяа биш л дээ, би зүгээр л яадгийг нь үзэх гэж тэгсэн юм. Харин намын юм уу, комсомолын гишүүний гэр бүлд сүсэгтэй хүн байх юм бол тэр гишүүн ёстой муугаа үзнэ. Ам бүлийнхээ хүнийг яагаад олигтой хүмүүжүүлэхгүй байна? гээд шахчихна. Сүсэглэдэг хүн өөрөө хаа нэг газар ажил хийдэг бол бас муугаа үзнэ: гавшгайч болгохгүй, шагнал урамшил олгохгүй, “хувраг”, “хийдийн дагуул” гэхчилэнгийн элдэв хоч наачихна.

-Уул нь ийм асуулт оруулах хэрэггүй байсан юм гэж Михаил Юрьевич Варятай ам нийлэв. -Хувьсгалын дараа анхны тооллого 1920 онд болсон. Асуулгын хуудсанд шашин шүтлэгийн тухай асуулт орсныг Ленин үзээд, шууд үүрэг өгч хасуулсан, эрх зүйд нийцэхгүйг мэдэж байхгүй юу. Саяны тооллогод бол утгагүй юм их бий, Варенька минь. Тооллогыг анхандаа 1936 оны эцсээр, аажуу уужуу таваас долоо хоногт багтааж явуулахаар төлөвлөж байснаа гэнэт бүх юм өөрчлөгдөж, 1937 оны нэгдүгээр сард шилжүүлэн г а н ц өдөрт багтааж явуулах тушаал буулгасан, хичнээн тоологч хэрэгтэй болсныг төсөөлж байгаа биз дээ? Сая гаруй тоологч. Улс орныг бүхэлд нь ганц өдрийн дотор тойрно гэж хүний толгойд багтах уу? Хот суурин газар ч бүтэхгүй, хөдөөг бол ярихын ч хэрэг алга. Гэтэл биелүүл гээд л тушаачихаж байгаа юм!

-Ингэхийн хэрэг юу байна аа, Михаил Юрьевич?

-Би өнгөрсөн удаа танд ярьж байсан. Тооллогоор хүн амын тоо 170 саяын багцаанд гарах ёстой, засгийн газар үүнд итгэлтэй байгаа, би хувьдаа бол их л сайндаа 164 саяас илүү гарахгүй гэж үзэж байна. Тэгэхээр зургаан сая хүн хаачив гэсэн асуулт гарна аа даа? Үүнд засгийн газрын өгөх хариулт тодорхой: тооллогыг хорлон сүйтгэх санаагаар явуулсан, тоологчид нь хорлон сүйтгэгчид.

түүний хоолой чичрэв.

Ард түмнээс үүнийг нуухын тулд нэг өдөрт багтаан тоол гэж тушаачихаад, дараа нь бүх бурууг нь тоологчид руу чихэх гэсэн санаатайг Варя сая л ойлгов. Ёстой тийрэнгүүд! Михаил Юрьевич тэгээд л бухимдаад байгаа юм байна.

-Михаил Юрьевич, та тайвшир, санаа зовохын хэрэггүй!

-Би санаа зовоогүй ээ. Гэхдээ юуг ч нуух хүсэлгүй байна, нуух ч үгүй. Зургаан сая гээд л бодчих! Энэ юун хүмүүс вэ? Жирийн тариачид. Тэдний буруу юу вэ? Юуны учир үрэгдэцгээв? Ямар ч буруу байхгүй, ямар ч учиргүй үрэгдэцгээсэн. Үүнийг нуухын аргагүй, нуувал ёс суртахуунгүй хэрэг болно. Тийм учраас, Варенька, би санаа зовоогүй. хүн амьтныг л өрөвдөх юм. Амь үрэгдэгсэдийг ч өрөвдөж байна, тооллого явуулсан, түүнийхээ төлөө хариуцлага хүлээх улсыг ч өрөвдөж байна, та бид хоёр ч бас хөөрхий хэмээн Тэрээр цөхрөнгүй инээвхийлэв. -Ингэхэд, та бид хоёр энэ тухай дэмий ярьж байна. Варенька, та насандаа дэндүү ахадсан хэрсүү зан гаргах юм. Яагаад театр, музейгээр явахгүй байна, өчнөөн сонин сайхан үзэсгэлэн одоо гарч байна шүү дээ.

-Та өөрөө явж байна уу? гэж Варя асуув.

-Би бол хөгшин толгой... Та Пушкины үзэсгэлэнг үзсэн үү?

-Үзэлгүй яхав.

-Ямар санагдав даа?

-Аятайхан санагдаагүй шүү. Яг орох хаалганы тэнд нэг зураг өлгөөтэй байсан... Наталья Николаевнагийн өндөр байгаа гэж, нуруу нь нүцгэн сүрлэг ч гэж жигтэйхэн, нүүр нь харагдахгүй зөвхөн нуруу нь ил, тэгтэл хажууд нь Пушкин гэж түүнээс мухар тохой хэртэй намхан, паравгар уруултай, хардаж хорссондоо нүүр нь ярвайчихсан юм уу гэмээр эрэмдэг юм эргэж хараад зогсож байна. Хүүхэн хичнээн ялгуусан дүүхэгэр харагдаж байна, гэтэл наадах нь гэж царай дортой атигар амьтан хөлд нь ороолдоод... Бүхэлд нь харахаар эргэн тойрны бүх хүн түүнийг дооглоод байх шиг, мань хүн бүгдээрэн рүү нь дайрч, толгой дараалан багалзуурдаж алахад бэлэн байх шиг. Пушкин биш, нэг муу адайр ааштай сармагчин гэлтэй. Тэгж зурж болно гэж үү?

-Та дэндүү шулуухан ярьж байна хэмээн Михаил Юрьевич эвгэйхэн зөрөв. -Би тэр зургийг чинь мэднэ. Николай Павлович Ульяновыг би өндөр үнэлдэг юм, түүний зураг. Мөн ч хурц нүдтэй дээ. Ер нь сэтгэл зүйн хөрөгний мастер. Пушкины сэдвээр их ажилласан хүн. Тэр зурагнаас шүүмжлэх юм байж болно, гэхдээ та буруу үнэлж байна. Тухайлахад, Наталья

Николаевнагийн нүүр байгаа шүү дээ, толинд харагдаж байгаа.

-Өө, нээрэн тийм шүү дээ, би мартчихаж. Гэхдээ бардам сүрлэг, тоомсоргүй нуруу л нүдэнд эхлэж тусаад байгаа юм.

-Тэр зураг чинь “А.С.Пушкин, Н.Н.Пушкина хоёр ордны бүжигт наадам дээр” гэдэг нэртэйг та яагаад анзаарсангүй билээ. Ульянов тэднийг яг шатны эргүүлгэн дээр байгаа мэтээр зурсан, их сонин байршил. Пушкины тухайд бол... Ульянов хурц үзүүрт өнцгөөр зураасаа гаргадаг, түүгээр Пушкины бухимдсан дүр тодорч буй. Энэ зургийг хорин долоон онд зурсан юм, би эхний хувилбарыг нь үзсэн, тэнд Пушкины царай өөр байсан. Тэр хувилбар таны сэтгэлд илүү нийцэх байсан байх. За, тэр яахав, үзэсгэлэн дээр өөр олон сонин зураг байсан шүү. Та бол дэндүү хэрсүү байна гэж би түрүүн хэлсэн. Варя, та одоо хэдтэй вэ?

Варя инээж,

-Эмэгтэй хүний насыг асуудаг юм уу? гэв.

Тэгснээ санаа алдав:

-Хүүхэд байхдаа би элдвийг ургуулан боддог, юм болгон ер бусын, оньсого шиг санагддаг байлаа. Байшингийн гэрэлтэй цонх, сарны туяа, гудамжны чийдэнгийн гэрэл энэ тэр... Ресторан чинь эхлээд шидэт ертөнц гэгч нь юм болов уу гэж бодогдоно. Хөгжим, гоё ганган хувцастай хүмүүс... Энэ бүхэн, хоосон зэрэглээ гэдгийг хожим нь ойлгосон. Нэгмөсөн тэжээвэр нууц амраг болчихвол ресторан хэсээд явж болно, яая гэхэв. Гудамжны хүүхнүүд чинь толгой ч үгүй, сэтгэл ч үгүй эгэл хорхойнууд. Амьдрал ресторанд байдаггүй, амралт цэнгээний газарт байдаггүй, амьдрал бол зовлон бэрхшээл, зүтгэл тэмүүлэл, амьдрал бол ажил сургууль, шоронгийн гаднах оочер, худал хуурмаг, шударга бус аймшигтай юмаар дүүрэн байдгийг тэгж явж мэдсэн. Амьдрал ямар ч байлаа гэсэн түүн дотор өөрийн гэх байх сууриа олох хэрэгтэй. Би зөв ярьж байна уу, та юу гэж бодож байна?

Варя Михаил Юрьевичид Сашагийн тухай огт яриагүй билээ. Михаил Юрьевич бүгдийг нь гадарлаж байгаа гэж тэрүүхэндээ боддог байж. Тийм биш гэдгийг одоо бол мэднэ. Энэ байрны зэргэлдээ өрөөнд Тэрээр Костятай сууж байсан юм чинь Михаил Юрьевич түүнийг нөхөртөө хайртай л гэж бодож яваа шүү дээ.

Ямар ч аугай тохой нь цэвэрхэн нөхөөстэй гэрийн эрээн хүрэмтэй энэ ахимаг насны, сэтгэлд дотно гань эр Сашаг тойрон эргэж буй ертөнцийн нэгэн хэсэг яах аргагүй мөн. Яг энэ буйдан сандал дээр суугаад Саша Михаил Юрьевичтэй ярилцдаг, яаж ажиллаж буйг нь ажигладаг, номноос нь авч үздэг асан.

Михаил Юрьевич байнга ном хэвлэлээ тордож янзалж байдаг хүн чинь өнөөдөр нэг л биш ээ, ганц хуудас наах нь битгий хэл, цавуу хайчаа цааш нь түлхэж харагдана.

-Таны бие төдгүй байгаа юм уу? Та хэвтэж амар, би явья гэж Варя санаа зовнингүй өгүүлэв.

-Үгүй ээ, Варенька, би огт зүгээр гээд өвгөн түр чимээгүй болсноо, ор, ширээ энэ тэрийн

доогуур буй сагстай сэтгүүлүүд рүү зааж, -Варенька, та миний сэтгүүлийг харж байсан байх аа, сонирхож байсан бил үү? гэв.

-Тэгсэн, ёстой сайхан сайхан сэтгүүл байна лээ.

-Юу л даа... Энд олон жил тоосонд даруулж байгаа юм. Уул нь Бенуа, Сомов, Добушинский энэ тэрийн уран бүтээлийн хичнээн сайхан хэвлэмэл хуулгууд энэ дотор бий гээч... Надад хааяа нэг эргүүлж үзэх ч зав гарахгүй юм. Эдгээр сэтгүүлийг та ав!

Варя балмагдаж орхив.

-Яана гэнэ ээ? Михаил Юрьевич... Яаж болохов? Энэ чинь маш их үнэтэй эрдэнэсийн сан. Бүх насаараа цуглуулчихаад одоо болохоор тараагаад байх юм уу?

-Би тарааж байгаа юм биш хэмээн Михаил Юрьевич гунигтай инээмсэглэв. -Би үүнийг танд бэлэглэж байгаа юм.

-Тэгвэл миний төрсөн өдөр болох яагаа ч үгүй байна.

-Бэлгийг зөвхөн төрсөн өдрөөр өгдөг юм биш. Варенька минь, та үүнийг ав, за юу. Би их баярлана шүү. Би хөгшин ганц бие хүн, намайг үхэхээр энэ бүхэн үрэн таран болно.

-Үхлийн тухай та битгий ярь! Ийм юм ярьж болохгүй гэж Варя цухалдав.

-Энэ тухай ярихгүй байж болно, гэхдээ бодож байх хэрэгтэй. Ийм сэтгүүлийг гар дороо байлгаад, дуртай цагтаа үзэж байхад танд сайхан байхгүй юу.

-А-аан хэмээн Варя инээв. -Та миний гоо зүйн мэдлэгийг дээшлүүлэх нь ээ дээ?

-Варенька, би таныг харанхуй хүн гэж үздэггүй. Хаанаас даа, харин ч яг эсрэг бодолтой шүү! Гэтэл урлагийн бүтээл орон доогуур юм уу, ширээн дээр хэвтэж байх ёсгүй, тэгэх гэж бүтээгээгүй нь мэдээж. Варенька, та л авч үз!

Варя толгой сэгсрэв.

-Үгүй ээ, Михаил Юрьевич, тэгж яаж болохов.

Михаил Юрьевич бодолхийлэв.

-За, яахав. Бэлэг авмааргүй байгаа бол больё. Харин эднүүс зүгээр л танайд байж байг. Уншихыг нь уншиж, харахыг нь харж сэтгэлээ сэргээж бай. За юу? Хожим би буцаагаад авна.

-Гэтэл би бас хаанаа хийхэв? Ялгаагүй л ор юм уу, ширээн доогуур хийж таарна.

-Танайд номын шүүгээ байхгүй юм уу?

-Байгаа л даа, гэхдээ дүүрэн номтой.

-Танд номын шүүгээ авчирч өгнө! Нээрэн шүү. Би нэг хээгүй шүүгээ авчихна. түүнийг танд авчирч өгнө. Манайд тавих газар байхгүйг та харж байна.

-Та заавал тэгэх гээд байгаа бол яая гэхэв хэмээн Варя итгэл муутай өгүүлэв.

-Харин тийм ээ, би заавал тэгэх гээд байна гээд Михаил Юрьевич сэргээд ирэв. -Би ном, сэтгүүлдээ дарагдчихаад байна. Чи авбал их тус болно шүү.

Парисаас далаад километрийн зайтай Эгревиль гэдэг жижигхэн хотын “Аялагчдын буудал”-д тэд нар Скоблинтой уулзав. Скоблины машины мотор эвдэрч, Гретцэд арга буюу саатсаны учир Тэрээр хожимдож иржээ.

Энэхэн үдийн үес хүн амьтны хөлгүй буй бэржээхэн саравчтай сэхээвчний нэг буланд тухлан сууцгаав. Шпигельглас Шарокийг Шаровский хэмээн танилцуулав. Скоблин түүнтэй хайхрамжгүй гар барьсан төдийгүй хүйтэн царайлан, тоомжиргүй буй нь илт. Тэрээр Шпигельгласын асуултыг хүлээж ёсорхсонгүй, шууд илтгэж эхлэв.

Ажилбарыг улс төрийн цагдаагийн газрын дарга Гейдрих эрхлэн явуулах ёстой, шууд удирдах үүргийг Беренс хүлээсэн. Беренст Тухачевскийн гарын үсэг зурсан баримт бичиг хэрэгтэй, тэр нь германы тагнуулын алба “абвер”-ийн архивт буй. “Абвер”-ийн дарга дэд адмирал Канарис тэр баримт бичгийг өгөхөөс татгалзсан.

-Яагаад?! хэмээн Шпигельглас хөмсөг зангидав.

-“Абвер” улс төрийн цагдаагийн газарт хамаардаггүй, Канарис Гейдрихт захирагддаггүй юм. Ямар нэгэн чухал хэргийг өөрийнх нь ар худрагаар хийж буйг Канарис мэдэрсэн. Ямар зорилгоор түүнээс баримт бичиг шаардаж буйг Тэрээр мэдэх эрхтэй төдийгүй мэдэх үүрэгтэй. Тэр бичиг нь арван таван жилийн өмнөх бичиг байсан ч ялгаагүй.

ЗСБНХУ, Герман хоёр нягт хамтран ажиллаж байсан хориод оны эх буюу дунд үеийн тухай яригдаж буйг Шарок ойлгов. Тэгэхэд Тухачевский яриа хэлэлцээ хийж, баримт бичигт гарын үсэг зурж байжээ. Эдүгээ шинэ баримт бичиг хийхийн тулд хуучин нь хэрэг болсон юм байж.

-Тэр баримт бичгүүд дээр рейхсверийн дээд офицеруудын гарын үсэг бас байгаа учраас тэдэнд гай тарихаас Канарис эмээсэн байж мэднэ хэмээн Скоблин үргэлжлүүлэв. -Өөрт нь Тухачевскийн холбогдолтой ажилбарын тухай мэдээлээгүй учраас Канарис улс төрийн цагдаагийн газар армийн удирдлагын хөлд дэгээ тавихаас болгоомжилсон биз. Уул нь Канарис герман-зөвлөлтийн өнгөрсөн үеийн хамтын ажиллагаанд холбогдох архивын бүх баримт бичгийг Гейдрихт шилжүүлэхийг тушаасан Рудольф Гессийн нууц албан бичгийг бүр нэгдүгээр сард авсан юм. Гэвч Канарис зөрүүдлэн, элдэв шалтаг зааж Гессийн тушаалыг биелүүлсэнгүй.

Шпигельгласын царай хөшсөн мэт болчихож. Тэрээр тайван төв дуугаар,

-Гитлер энэ ажилбарыг сайшаасан, тэр ч атугай, “Энэ бол зул сарын баяраар Сталинд барих түүний бэлэг” хэмээн тоглож хэлсэн гэж та өнгөрсөн удаа мэдээлсэн шүү гэж хэлэв.

-Би гарцаагүй найдвартай эх сурвалжаас үндэслэн илтгэсэн гэж Скоблин зөрөв. -Баримт бичгийг шилжүүл гэж Гитлер ө ө р ө ө Канарист тушаалаа ч гэсэн учрыг нь тайлбарлах ёстой. Тайлбарлахгүй байгаа бол итгэхгүй байна гэсэн үг. Канарис огцрох өргөдөл гаргахаас өөр аргагүй болно. Тийм учраас Гейс, Гейдрих хоёр Гитлерт нарийн ширийн зүйлийг танилцуулаагүй, Тэрээр баримт бичиг аль архивт байгааг ч мэдэхгүй.

-Ямар гарц байна? гэж Шпигельглас асуув.

-Гарцыг Борман олсон, фюрерийн улс төрийн зөвлөх.

-Борман хэн болохыг надад тайлбарлах хэрэггүй.

Шпигельглас дургүйцлээ нууж чадахгүй байгааг Шарок анх удаагаа харав.

-Та миний үгийг тасдчихлаа. Борманы зөвлөсний дагуу Гейдрих нэг шөнө архив руу цагдаагийн хоёр бүлэг явуулсан гэж Скоблин жишимгүй өгүүлэв. -Тэд нар эвдлэх ажлаар мэрэгшсэн хүмүүсийн туслалцаатайгаар холбогдох материалыг олж аваад, ул мөрөө баллахын тулд гал тавьсан гэнэ. Материал одоо Беренс, Найуйокс хоёрт ирсэн, тэд туршлагатай сийлбэрчидтэй ажиллаж байгаа. Баримт бичгүүд долоо хоногийн дараа бэлэн болно, гэхдээ зөвхөн Тухачевскийд холбоотой нь.

-Бусад нь.

-Якир, Уборевич, Корк гурав Тухачевскийг бодвол Германд ховор очиж байсан, бас хориод оны баримт бичигт гарын үсэг зурж байгаагүй юм байна. Тэдэнд холбогдох үндсэн эх тун ховор. Тийм материал бэлтгэхэд зохих хугацаа шаардагдана.

-Надад бүх хүний материал хэрэгтэй, долоо хоног хүлээж болно, харин илүү хүлээх боломжгүй гэж Шпигельглас эрсхэн хэлэв.

-Би тэр материалыг бэлтгэдэг юм шиг та надтай ярьж байна.

-хэн бэлтгэдгийг би мэднэ гэж Шпигельглас зөрөв. -Гэхдээ түүнийг хоёрдугаар сард, дараа нь гуравдугаар сард надад өгсөн байхаар хэн амласныг би санаж байна, гэтэл одоо, яруу найрагчдын хэлдгээр, хотон дотор дөрөвдүгээр сар налайж байна.

-Саатаж буйн шалтгааныг би сая тайлбарлалаа.

-Тэгвэл цаашид сунжрах юм бол тэдгээр баримт бичиг ерөөсөө шаардлагагүй болно гэдгийг германыханд тайлбарлахыг хүсье.

-Германыханд би юу ч тайлбарлаж чадахгүй! Тэдний ямар хичээнгүйг, яаж цаг баримталдгийг та мэднэ. Тэд нар чанарыг нь өөрснөө бүрэн хариуцаж чадах, яагаад ч няцаагдашгүй баримт бичгийг л хүнд өгнө. Яарах уу, найдвартай юм авах уу гэдгийн аль нэгийг сонгох болж дээ.

-Найдвартай байх явдал чухал, гэхдээ хугацаа ч бас чухал гэж Шпигельглас сургамжлан өгүүлэв. -Таны мэдээллийг үндэс болгон би удирдлагадаа хугацааны тухай хэлсэн. Тэр хугацааг би хоёр удаа хойшлуулсан, одоо гуравдахиа хойшлуулж чадахгүй. Би одоо нэг долоо хоног хүлээж болж байна, гэхдээ энэ бол сүүлчийн долоо хоног шүү, ирэх лхагва гаригт яг энэ цагт бид энэ сэхээвчинд байж байя. Ямар нэг шалтгаанаар Эгревиль танд тохиромжгүй болвол шинэ газрын тухай холбоо барьдаг сувгаараа мэдэгдээрэй. Таныг маргаашаас оройгүй Берлин рүү гарна гэж найдаж байна.

Шарок, Шпигельглас хоёр дараачийн долоо хоногийг элчин сайдын яамнаас холгүй орших жижгэвтэр зочид буудалд өнгөрөөв. Зөвлөлтийн ажил хэргийн хүмүүс энд голчлон буудаг бөгөөд харьцангуй хямд үнэтэй умгар өрөөнүүдтэй аж.

Шпигельглас Шарокийг нэг ч алхам өөрөөсөө холдуулахгүй байв. түүнийг хянах буюу аюулгүй байдлыг бодсондоо бус өөрөө түүний хараанд байнга байх гэсэндээ ингэсэн аж. Тэгж гэмээ нь Шарок Москвад очсон хойноо, “Бид хоёр ганц минут ч хагацаагүй” гэж хэлэх үндэстэй байх юм. Тэр ч байтугай, Шпигельглас зочид буудалд орохдоо, жаахан бодсоны дараа, дундаа нэг өрөө авна гэжээ. Буудлын хүлээн авагч гайхаж хоцорчээ:

-Un lita deux places.*

-Non, deux lita une place.**

Шпигельглас дараа нь бөөн инээд болсон:

-Тэр үйлчлэгч биднийг бандидагчид гэж бодож!

Шпигельгласт энд Скоблиноос гадна өөр ажил явдал байгаа нь зайлшгүй боловч, Тэрээр өөр хэнтэй ч уулзсангүй, мань хоёр өдөр, шөнө ялгалгүй цуг байцгаав. Шарокт тэр болгоныг мэдүүлэхийг хүсэхгүй байна уу? Яваандаа түүнийг гадаад хэлтсээс зайлуулна гэж найдаж байх нь.

Ажигч гярхай Шпигельглас энэ сэжгийг өөрөө арилгав:

-Бидний энэ аялал таныг Парист буй манай өөр хэд хэдэн туршуултай танилцах боломж олгож байгаа юм. Гэвч бидэнд өгсөн үүрэг нэн хариуцлагатай учраас бид аз турших эрх байхгүй, цагдаагийнхан биднийг нэг анзаарчихвал Скоблинтой болзсон цагтаа уулзахад саад хийж мэднэ. Ер нь цаашид танд зөвлөхөд, нэг удаагийн аялалаар нэг л туршуултай уулзаж байх нь зүйтэй.

Өдөр нь тэр хоёр худалдааны төлөөлөгчийн газраар орж, жирийн нэг мэргэжилтний өрөөнд энэ тэрийг хөөрөн суух хооронд Шпигельглас долоо хоног саатах болсноо Москва руу мэдэгдэв.

Ажилбарын агуулга одоо Шарокийн хувьд нууц биш болов. Гэхдээ мань хүн энэ тухай Шпигельгласаас биш, Скоблин тэр хоёрын ярианаас мэдэж авчээ. Хэрвээ хожим түүнээс “Энэ тухай Шпигельглас юу ярьсан бэ?” гэж асуувал Тэрээр, “Юу ч яриагүй гэж хариулах ёстой болно. Тэр хоёр ЕЖ-13 дугаарын туршуул Скоблинтой Тухачевский, Якир, Уборевич, Корк нарын урвасныг илчлэх баримт бичиг гестапогоос олж авах асуудлаар яриа хэлэлцээ хийж байна. Тэр бичиг цаас жинхэнэ баримт мөн эсэх нь тэдэнд падгүй. Тэр хоёр уг баримтыг о л ж а в а х л ёстой, мөн бишийн учрыг бусад хүн олно.

Тэр хоёр зөвхөн Скоблины тухай л илэн далангүй ярьцгаана.

Скоблин Шарокт таалагдсангүй. Тэрээр түүнийг овилгогүй шинжтэй, дотуур тамиртай, бас

хэлсэн амандаа эзэн болдоггүй хүн гэж дүгнэв. Москвад түүний мэдээлэгч нар гар хоосон ирж зүрхлэхгүй шүү дээ. Энэ тухайд Шпигельглас,

-Ийм юм л даа. Манай дотоодын мэдээлэгч, хилийн чанад дахь туршуул хоёрыг ямар ч утгаар жишиж болохгүй хэмээн _____

* Хоёр хүний өргөн ортой юу? (франц)

** Үгүй ээ, нэг хүний хоёр ортой (франц)

тайлбарлав. -Манай мэдээлэгчийг бид хамгаалж байгаа, туршуул бол хутганы ирэн дээр байгаа хүн. Манайхан намдаа үнэнч буюу үзэл бодолдоо эсвэл айдастаа хөтлөгдөнө, бид түүнийг ойлгож байгаа, заримдаа мөнгө, албан тушаал, элдэв хангамж мэтийн хар амиа бодсон шуналд хөтлөгдөх нь бий. Эндхийн туршуулд бол саяны хэлдгүүдээс хавьгүй чухал улс төрийн хонжоо, давхар мэх, адал балмад санаархал зэрэг өдий төдий сэдлэг бий. Энэ үүднээс авч үзвэл “Фермчин” нэг тодорхой жишээ. Энэ а ж и л б а р ы г хувьдаа их сонирхож байгаа. Яагаад гэвэл зөвлөлт засагт зүтгэж байгаа хааны үеийн хуучин офицеруудыг үзэн яддаг юм. Тэднээс болж иргэний дайнд цагаантнууд ялагдсан. Тухачевский тэр үеийн дэслэгч, Корк дэд хурандаа, Уборевич бага дэслэгч. Скоблин тэднийг урвагчид гэж үздэг учраас залхаан цээрлүүлэхийг хүсч байгаа юм. Атаархал бас зохих үүрэгтэй: Тухачевский тэр хоёр нас чацуу, хоюулаа 1893 онд төрсөн, гэтэл Тухачевский дэлхийд цуутай цэргийн жанжин, мань Скоблин авьяаслаг цэргийн хүн мөн мөртлөөсөө авгайгаараа тэжээлгэж байгаа, хэн ч мэдэхгүй цагаачин. Ер нь бол эндхийн туршуул болгон том толгой, хүн нэг бүрийг нягтлан судлах шаардлагатай, тийм учраас та шинэ нөхцөл байдалд дасах хэрэгтэй.

Шпигельглас Шарокт Парис хотыг үзүүлэв. Елисейн талбайгаар зугаалцгааж. Эйфелийн цамхаг дээр гарч, хотыг дээрээс нь харцгааж. Монмартр, Поле-Рояль, Версаль руу очицгоож. Хөндлөнгийн хүний анхаарал татахгүйн тулд хоорондоо францаар ярилцаж явжээ. Гэхдээ Шпигельглас голчлон ярьж, Шарок толгой дохих төдий, хаа нэг ганц үг, өгүүлбэр хавчуулна. Шпигельглас тайлбарлагч шиг харагдана. Тэрээр Парисыг сайн мэднэ, боловсрол сайтайн хувьд францын утга зохиол, урлагийг бас мэднэ. Гэвч түүнийгээ Шарокт харуулахаас түвдэж, нарийн ширийн юм руу эс гүнзгийрч, Парисын тухай ердийн экскурсины хэлээр тайлбарлаж өгнө.

Гэвч жуулчдын уламжлалт газрууд Шарокийн сонирхлыг төдий л татсангүй... Лувр юу юм бэ?! Бүр сургуульд байхын ангиараа Третьяковкийг үзэхэд мань хүн уйдаж үхэхдээ хүрдэг байсан юм чинь. Харин Версаль, Поле-Рояль бол ч... Хаадууд амьдарч чадаж байж, ярих юм алга. Парис хааны хот гэж Шпигельглас зөв хэлсэн байна. Яах аргагүй сүрлэг, тансаг байна, тэглээ гээд яах вэ дээ? Манай Петергофт ч бас гоё шүү дээ.

Харин Фоли-Бержер, Пигалийн гудамж, нүцгэн шахуу янханууд, порно ил захидал, сэтгүүлийн жижигхэн дэлгүүрүүд энэ тэр бол өөр хэрэг. Шарокийн зүүдлээ ч үгүй олон янзын арга, хувилбар байдаг юм байна, тогтоож авах юм шүү, харьсан хойно Калятай туршиж үзэх хэрэгтэй... Шарок тийм газар хэдэн цагаар шахцалдсан ч сийхгүй, сэтгэлийн цэнгэл эдлэж болохоор байтал Шпигельглас садаа болоод яах ч арга байдаггүй, дэмий л өөрийгөө

албадаж уйдсан дүр эсгэнэ.

Тэгэвч нэг удаа тэсэлгүй,

-Монмартр руу дахин нэг очвол яасан юм? хэмээжээ.

-Бололгүй дээ.

Монмартр хөл ихтэй, хөгжөөн цэнгээнтэй учраас Шарокийн дурыг татжээ. Гитар дүнгэнэн, гар эргүүлэгтэй баян хуур эгшиглэж, задгай цамцтай зураачид хоорондоо уралдах мэт дандаа шалдан хүүхэн зурцгаана. Зурах гэж үзүүлээд өгнө, хөх, бэлхүүс, хөл-энэ тэр гэж сүүрс алдмаар...

Шпигельглас энэ бүхнийг юман чинээ тоохгүй, эмс хүүхнийг ч эс сонирхоно. Хатанги годил! Тэрээр нэг удаа, “Парис дэлхийн хамгийн их хөл үймээнтэй хот хэрнээ алжаал тайлахад бусдыгаа дагуулахгүй” гэж хэлсэн. Тэр нь аргагүй үнэн юм. Ганц аяга кофе захьчихаад л хоёр цаг сонин эргүүлээд суучих бол юу ч биш. Хөөнө тууна гэж ёстой байхгүй. Шпигельглас өрнөдийг үнэн санаанаасаа үзэн яддаг бололтой, янхан хүүхэн, порно зураг энэ тэрийг капиталист нийгмийн идээ бээр хэмээж, мөнгө хүүлэгчдийг хөрөнгөтний хамгийн хортой шимэгч хувалз гэж муулан, хавтгайдаа ядуу зүдүү байхад элдэв тансаг юмаар гайхуулж буйг шогцрон халаглана.

Шарок дуугүй толгой дохино. Маргаад ашиггүй бас аюултай. Шпигельглас хашир хүн учраас өрнөдийг зориуд өөрийнх нь нүүрэн дээр муулж байж ч мэднэ.

Тэр хоёр долоо хоногийн дараа нөгөө л “Аялагчдын буудал”-даа, нөгөө л сэхээвчиндээ Скоблиныг хүлээж байв.

Цаадах нь энэ удаа хожигдсонгүй.

Сэхээвч аанай л хүнгүй байсан тул тэр гурав түрүүчийнхээ ширээ рүү очиж сууцгаав.

Скоблин цүнхнээсээ улаан хавтас гаргаж Шпигельгласын урд тавив.

Шпигельглас Шарокт зэрэг харуулахаар түүн рүү яльгүй дөхүүлээд уг хавтсыг нээлээ. Баримт бичиг нь герман хэл дээр байх тул Шарок юу ч ойлгосонгүй. Орос хэл дээр ганцхан бичиг байсан нь, улс төрчдийг зайлуулж, засгийн эрхийг булааж авах хэрэгтэй хэмээсэн Тухачевскийн захидал ажээ. Дараа нь босоогоор нь жагсаасан баахан тоо гарав. Тоо болгоны ард Тухачевскийн гарын үсэг байхыг үзэхүл тагнуул хийснийхээ хөлсийг авсан нь тэр бололтой. Тэр хавтсан дотор Троцкийн германы цэргийн түшмэдтэй авахуулсан зураг байхыг Шарок харав.

Шпигельглас хавтсаа хаалгүй,

-Ингээд гүйцээ юү? гэж асуув.

-Гүйцээ гэж Скоблин өчив.

-Энд зөвхөн Тухачевскийд холбогдох баримтууд байна. Бусад нь?

-Би танд хэлсэн шүү дээ: Хоёр сараас доошгүй хугацаа хэрэгтэй. Тэд нар энэ хугацааг нотлосон. Юу ч өөрчлөх арга байхгүй.

Шпигельглас чимээгүй азнаснаа,

-За яахав. Тодруулж хэлбэл яая гэхэв. Байдал мухардмал байгаа юм байж. Тийм үү, би зөв ойлгож байна уу? гэв.

-Яагаад мухардмал гэж? хэмээн Скоблин зөрөв. -Бусдад нь холбогдох материалыг та яг хоёр сарын дараа гардаж авах болно.

-Хийдгээрээ хийг гэж Шпигельглас хөрсгөр царайлан өгүүлэв. -Бидний уулзах газар, яг хөдөлбөргүй хугацааг холбоо барьдаг сувгаараа мэдэгдээрэй. Хоёр сараас оройтож болохгүй. Эрт бол бүр сайн. Би юм уу, ноён Шаровский ирнэ, бид хоёр ч дахиад ирж магадгүй.

Үйлчлэгч тооцоог ширээн дээр тавьжээ. Шпигельглас хянамгай харснаа түрийвчээ гаргаж, дийзэн дээр мөнгөө тавьснаа, нэгэнтээ бодолхийлээд, хоёр зоос нэмэв.

Сталин 1937 оны тавдугаар сарын 1-нд Мавзолейн индэр дээрээс цэргийн парад хүлээж авлаа.

Василий Блаженныйн сүмийн дээгүүр мандсан нар нүүрэн талд нь түүний аврага том хөргийг хадсан ГУМ-ын байшинг гийгүүлж байна. Бүх юм гялалзаж гялтганан туяарч, хөгжим нижигнээд, дулаахан сайхан байна. Улаан талбай дээгүүр хамгийн түрүүнд цэргийн академиудын урт тэгшхэн жагсаал явж өнгөрөв. Араас нь буугаа жадлан барьсан явган цэрэг маршилж, тэдний дараа морин цэрэг талбайн чулуун замаар тожигнуулан одов. Тэгээд Түүхийн музейн тэндээс танкны цуваа талбай руу мөлхөх мэт орж ирэв. түүний арми, ялагдашгүй, хүчирхэг арми. ӨӨРИЙНХ нь зэвсэглэсэн, ӨӨРИЙНХ нь тоноглогсон арми. мань хүн улс орныг үйлдвэржүүлсэн, мань хүн улс орныг шинэчилсэн, дэлхийд томоохонд орох үйлдвэр завод барьж, хүрзэн зэвсэгтэй Оросыг дэлхийн гүрэн болгож хувиргасан.

Тухачевский цэргийн бусад дарга нарын тэрүүхэнд суран бүснийхээ цаагуур дөрвөн хуруугаа хийчихсэн зогсож байна. Ялгараад л байна даа. Бас түүнтэй ярих хүн ч алга, нэгэнт баларсныг нь зөнгөөрөө мэдэрцгээсэн хэрэг. Лондонд явуулахаа больсныг эсэргүүцээгүй, элдэв тайлбар ч шаардаагүй. Ежовын хэлсэнд үнэмшив үү? Эргэлзээтэй. Тэгэхээр хүч нь мөхөсдөж буйг мэдэрч байх нь. Цэргийнхнийг ид баривчилж байна, Шмидт, Путна, Примаков гурваас гадна олон хүн баригдсаны дотор корпус командлагч Туровский, Геккер, Гарькавый нар байгаа. Бас Тухачевскийд холбогдох материал бүрдчихлээ. Ягодатай цуг баригдсан түүний ойр дотнын туслахууд-Прокофьев, Гай, Волович энэ тэр Тухачевскийн талаар шаардлагатай мэдүүлгийг шууд өгсөн, өөрснөө олон жил хүмүүсээс худлаа домог албадан хэлүүлж сурсан болохоор юу хэлэхээ андахгүй, санаа амар юм, харин муу гайхал Ягода л ганцаараа зөрүүдлээд байгаа.

Цэргийнхнийг баривчилж байгаад Тухачевский тэгтлээ сандарч түгшихгүй буй. Дасчихсаных. Хориод оны сүүлч, гучаад оны эхээр армийг хааны үеийн офицеруудаас цэвэрлэж, тэднээс гурван мянга гаруйг нь хорих лагерьт явуулсан билээ. Тухачевский нөхдийгөө өмөөрөөгүй, “Би ч бас хааны үеийн офицер, тэгвэл намайг бас шоронд хий” гэж хэлээгүй. Яагаад хэлсэнгүй вэ? Офицер хүний сурвалжит нэр төр нь хаа байна? Цэргийн нөхөрлөл, эв санааны нэгдэл хаачив? Өөрийгөө онцгой байдалд байгаа гэж үзэж байхгүй юу. Цаадуул нь бол цэргийн жирийн мэргэжилтнүүд, мань хүн бол цэргийн дээд дарга, армийн “ноён нуруу”. Корпус командлагч Путнаг барихад ч хар аваагүй, түүнтэй, түүнгүй арми болно, мань хүнгүй бол арми явахгүй гэж бодож байгаа хэрэг. Эндүүрч байна даа. Их эндүүрч байна... Олон түмний ярьдагчлан, “манайд солигдошгүй хүн гэж байхгүй”.

Сталин цэргийн параданд дуртай. Ө ө р и й н х ө ө армийг харах дуртай. Арми аливааг хэлэлцэх ёсгүй, зөвхөн биелүүлэх үүрэгтэй, бурханаас заяасан заяа нь тэр, байлдагч тангараг өргөдөг учраас эргэлзэх тээнэгэлзэх явдал байхгүй, даргынхаа хүсэл зоригийг үг дуугүй биелүүлнэ. Доод дарга нар дээд дарга нарынхаа хүсэл зоригийг биелүүлнэ. Арми шиг нэгдмэл, зүгширсэн аппарат гэж хаа ч байхгүй. Армийн хүч ч энэ, түүний сул тал ч энэ, толгойг нь тасдаад хаячихангуут их бие нь ажиллагаагүй болчихдог юм.

Сталин цэргийн дарга нараа дахин нэг харав. Тухачевский суран бүснийхээ цаагуур хуруугаа хийсэн чигээрээ хуучин байрандаа зогсож байна. Парад явж байхад гараа ийм байлгах ёсгүй, гэтэл энэ нөхөр ингэж байна. Яасан ч яахав гэж байгаа юм шиг. Одоо, сануулах гол цохилт авснаасаа хойш яасан ч яахав болчихож. түүний баруун гарын найз, журмын нөхөр асан Николай Николаевич Кузьмины авгай, өөрийнх нь дотнын хүн Юлия Ивановна Кузьмина баривчлагдсан... Тэрээр аль нэг хүлээн авалт дээр түүнийг тогтож харсан удаатай, гойд харцтай, хорхой хүрэм хүүхэн байсан шүү. Мотовиловоор уран баримлын арга ухаан заалгадаг сэхээтэн хүүхэн. Юун барималч юм бол? мань хүн Мотовилов гэж барималчин сонсоогүй дээ. Нөхөр Кузьмин нь түүнээс хорь ах, харин Тухачевский бол арав ах. Сайхан эрийг ч хэлэх үү. Хүүхнүүд түүнд бүр амиа тавих юм, буудалцах, дүүжлэлцэхдээ хүрэхийг яана. Уул нь гэр бүлтэй хүн шүү дээ. Авгай, охин хоёр нь байна, өөрөө дөч гараад явчихлаа... Гэхдээ Кузьминаг баривчилсныг тэсэлгүй яахав. Бас туслах нь баригдсан... Тухачевскийд бүх юм тодорхой байгаа. Тийм учраас алгуурлаж болохгүй. Берлинээс материал ирсэн ч, эс ирсэн ч алгуурлаж болохгүй. Тэгэхээр мань хүн ч юу гэж алгуурлахав. мань хүн өөрийнхөө асуудлыг түүнтэй түүнгүй шийдэж чадна гэдгийг Гитлер мэдэж аваг.

Тухачевский хөдөлмөрчдийн жагсаалын үеэр үлдсэнгүй. Яваад өгөхийг нь мань хүн өөрөө харжээ. Тэгэхдээ индэр рүү огтхон ч эргэж харсангүй, ТҮҮН РҮҮ нэг ч удаа эргэж харсангүй. Тэрээр үүнийг анхааралтай ажигласан. Нэг ч удаа эргэж хараагүй, тийм учраас мань хүн түүний царайг энэ удаа харж чадсангүй.

Хөдөлмөрчдийн жагсаал дуусав. Ворошилов параданд оролцсон цэргийн дээд дарга нарт гэртээ зоог барив. Нөхөр Сталин ч энд байлцав. Хундага өргөж үг хэлцгээж. Нөхөр Сталин бас хундага өргөж. Тэрээр улс орны дотоод байдлыг товчхон томъёолж яриад, ажлын бүх салаа салбарт, түүний дотор армид хорлон сүйтгэх, тагнан турших явдал хавтгайрсныг дурдав.

-Дайснууд илчлэгдэх нь гарцаагүй, нам тэднийг будаа болгоно... Би энэ хундагыг нам, ард түмэндээ үнэнч хэвээрээ байж, Октябрийн хувьсгалын ойн баярын ширээнд нэр төртэй байраа эзлэх нөхдийн төлөө өргөж байна.

Нөхөр Сталины үгийг амьсгаа даран сонсоцгоожээ. Хагас жилийн дараа энэ ширээний ард сууж байна гэсэн итгэл тэр болгон хүнд байсангүй.

Майн баярын дараа Сталин цэргийнхний хэргийг гартаа авав. Ширээнийхээ том хуанлийн хуудаснуудыг эргүүлж үзэв. Нэг сар. Нэг сарын дотор бүх юмыг амжуулах хэрэгтэй. Зургадугаар сарын нэгэн гэхэд бүх юм дууссан байх ёстой. Одоо Ежов байцаалтын протоколыг Сталинд өдөр бүр авчирч үзүүлдэг, Сталин тэдгээрийг хянадаг, Ежов шорон руу буцаж очдог, хоригдлууд зассан протоколд гарын үсэг зурдаг, Ежов дахиад Сталин руу ирдэг болжээ.

Корпус командлагч Примаков есөн сарын турш мэдүүлэг өгсөнгүй. Тавдугаар сарын 8-нд түүнд одон тэмдэг, мөн ялгах тэмдэг энэ тэргүй цэргийн хувцас өмсгөж, нүдний шилийг нь

буцааж өгөөд, Кремльд авчирч, Сталины өрөөнд оруулжээ. Тэнд Молотов, Ворошилов, Ежов гурав хэдийн ирчихсэн сууж байв.

Примаковын Сталинд шоронгоос бичсэн захидлууд түүний ширээн дээр байна.

Сталин тэр захидлууд руу зааж,

-Би таны захидлуудыг уншсан. Та 1928 онд троцкийчуудаас шудрагаар салж, түүнээс хойш тэдэнтэй ямар ч холбоогүй яваа гэж бичсэн байна.

-Тийм ээ, энэ үнэхээр тийм юм гэж Примаков хариулав.

-Та энд, Улс төрийн Товчоон дээр хүртэл намыг мэхэлсэн хэвээр байна гэж Сталин хэлэв. - Таныг Дрейцер, Шмидт, Путна болон бусад троцкийчуудтай холбоотой тухай няцаагдашгүй баримт бидэнд байна. Армид хуйвалдаан байгаа тухай, нөхөр Ворошиловын эсрэг хуйвалдаан байгаа тухай няцаагдашгүй баримт манай намд бий. Та нар Ворошиловыг Якираар солих тухай хэлэлцсэн, бид үүнийг бас мэдэж байгаа.

Тэрээр Товчооны бусад гишүүн рүү эргэв:

-Примаков-аймхай этгээд, ийм илт хэргээс булзана гэдэг бол хулчгарынх. Бид алдаа хийжээ: Примаков бол намын удирдлага яриа хэлэлцээ хийхээр гавьяатай хүн биш. Энэ хүн намын хэлийг ойлгохгүй байна, тэгвэл яая гэхэв, мөрдөн байцаагчид түүнтэй өөрийнхөө хэлээр ярина биз. Энүүнийг аваад яв.

Примаковыг тэндээс гаргаж машинд суулгаад, нар гийж, баярын өмсгөл нь гялалзсан, түм түчигнэж, бум бужигнасан Москва хотын дундуур давхиулж, шорон руу авчраад өрөөнд нь хийж, нүдний шилийг нь хурааж, цэргийн хувцасных нь оронд өмхий навтсыг нь буцааж өмсүүлэхийг тушаажээ.

-Миний шилийг үлдээгээч, бас цаас, бэх өгөөч, би нөхөр Ежовг өргөдөл бичмээр байна гэж Примаков хэлэв.

Примаковын шилийг үлдээж, цаас, үзэг, бэх авчирч өгчээ.

Тэрээр Ежовг ингэж бичив:

“Троцкист эсэргүү байгууллагын хэргийг мөрдөж буй байцаалтад би есөн сарын турш улайгаагүй. Эцэстээ бүр эрээ цээрээ алдаж, Улс төрийн Товчоон дээр, нөхөр Сталины өмнө хүртэл буруугаа элдвээр зувчуулан, хэрэг хүлээхээс булзахдаа хүрлээ. Нөхөр Сталин, “Примаков-аймхай этгээд, ийм илт хэргээс булзана гэдэг бол хулчгарынх” гэж шууд хэлсэн. Үнэхээр, энэ бол миний зүгээс гаргасан хулчгар зан, мэхэлсэндээ болоод худлаа ичсэн хэрэг мөн. Би 1930 онд Японоос буцаж ирээд, Дрейцер, Шмидт хоёртой холбоо барьсан, Дрейцер, Путна хоёроор дамжуулан Мрачковскийтэй холбоо барьж, троцкист үйл ажиллагаа эхлэснээ үүгээр мэдэгдэж байна. Энэ тухай мөрдлөгийнхөнд бүрэн мэдүүлэх болно”.

Тэрээр өргөдлөө өгч, ороо буулгаад хэвтлээ. Гүйцээ! Өнөөдөр түүнийг зодохгүй нь лав.

Ежов тэр даруй Сталинд утасдаж, Примаковын захидлыг уншиж өгөв.

-Бүрмөсөн бууж өгөхийг нь хар гэж Сталин өгүүлэв.

Тавдугаар сарын 10-нд Тухачевскийг Батлан хамгаалахын ардын комиссарын орлогчийн албан тушаалаас чөлөөлж, Куйбышев руу, цэргийн тойргийн даргаар томилов. Харин Якирыг Киевээс Ленинград руу шилжүүлжээ.

Тавдугаар сарын 12-нд Ежов ирж, Германаас авсан баримт бичиг бүхий улаан хавтсыг Сталины ширээн дээр тавилаа.

-За яахав, та яв, би наадахыг чинь харна аа гэж Сталин хэлэв.

Сталин ганцаараа үлдсэн боловч нэг хэсэгтээ хавтсыг нээсэнгүй. Хичнээн удаан хүлээсэн билээ, одоо хэдэн минут тэсч болно. Харваас дорвилог хүрэн улаан хавтас ширээн дээр нь байж байна. Нээрэн, удаан хүлээсэн шүү, харин одоо бол сэтгэл хөдлөх юм алга. Ц а г а а н д а а г а р ч и х а ж. Сайхан хэллэг шүү: хүлээж ядаад цагаандаа гарчихжээ. Тэгээд ч мань хүн Гитлерийн туслалцаагүй асуудлаа өөрөө хэдийн шийдчихсэн юм чинь. Гэхдээ материалыг үзэлгүй яахав.

Сталин хавтсаа нээв. Гуч орчим хуудас бүхий хэд хэдэн баримт бичиг байна. Тэдгээрийн доор хатуу хавтсанд хийсэн герман баримтын орос орчуулга байна. Троцкийн Германы томоохон түшмэдтэй авахуулсан зураг мөн байна.

Баримт бичгийн тэн хагас нь Тухачевскийн захидлууд аж. Чухамдаа гол баримт бичиг нь энэ. Түүн дээр “абверийн” “маш нууц” гэсэн тэмдэг даржээ. Бас Гитлерийн цохолт байна: Тухачевскийн захидлаар харилцаж байсан генералуудад ажиглалт тогтоо. Гитлерийн жинхэнэ гарын үсэг үү, хуурамч уу гэдгийг мань хүн эс мэднэ. Харин Тухачевскийн захиа бол... Сталин тун анхааралтай уншиж үзэв. Тухачевскийн бичиг, түүний гарын үсэг, түүний найруулга яах аргагүй мөн. Агуулгыг үзвэл, орос, германы генералууд хоорондоо тохиролцож, засгийн эрхийг булаан авч, улс төрийн удирдлагаас салах ёстой гэсэн санаа байна.

Мэдээж, энэ бүхэн зохиомол зүйл, гэхдээ аргагүй нарийн хийсэн зүйл бололтой, Герман ч мэрэгжилтэнтэй газар юм аа. Нөгөөтэйгүүр, дуурайлгах юм нь байсан л даа. Орос, Германы хамтын ажиллагааны үед буюу хориод онд Тухачевскийн бичсэн жинхэнэ захидлууд тэднийд хэд л бол хэд байгаа.

Тэрээр хориод онд германыхантай харилцаж байсан нууц захидлуудыг зориуд дахин уншиж үзэв. Захидлыг Тухачевский бичиж, Улс төрийн Товчоо батладаг билээ. Энэ нэг захидал яг жинхэнэ үлгэрээр нь хийгдсэн байна. Хоёрдмол санаа нь ч яг байна. Нууцаар хамтран

ажиллах гэж байгаа учраас тэгж бичихээс өөр аргагүй. Бас далд санаа нь ч яг. Аль нэгэн гуравдагч этгээдийн гарт орвол ойлгогдохгүй байх ёстой. Жишээлбэл, мэдээлэл солилцох тухай хэлэлцээрийг тагнуулын мэдээ дамжуулах мэтээр тайлбарлаж болно, эсвэл ердийн цэргийн аж үйлдвэрийн мэдээлэл солилцох утгаар нь ойлгож болно. Германчууд шорвог золигнууд! Үсэг болгоныг, ацаг шүд болгоныг дуурайлгаж гаргасан байна. Энэ бол хэтрүүлсэн хэ-рэг. Хориод оны хэлэлцээрүүдээс хуулсан зүйл гээд захын шинжээч төвөггүй нотлохоор болчихож. Одоо чинь гучаад он шүү дээ!

Баримт бичгүүдэд ганцхан Тухачевскийн нэр байна. Якир, Уборевич, Корк энэ тэр хаа байна? Манай элчин сайд Сурицыг ийш нь хавчуулчихаж. Яах гэж тэр вэ? Аян хамтад нь нэг еврейг шургуулахаар шийдээ юү? Троцкийн гэрэл зураг бас? Мэдээж, энэ зургийг аваад хаячихаж болно, гэхдээ германы тагнуулчдын түвшин ямар байна?!

Бас нэг зүйл. Гитлер өөрийнхөө генералуудыг бай болгохгүй байна. Зөнөг толгой фон Сект, тэр муу хэнд хэрэгтэй юм бэ! Гитлер генералынхаа багтай муудалцах бодолгүй байх нь.

Энэ өрөөсгөл баримт бичгийг нийтэлвэл мань хүн Гитлерээс хараат байдалд орно. Энэ хуурамч бичгийг, гестапо зохиосон, өөрийнх нь гарын үсгийг хуурамчаар үйлдсэн гэж Гитлер дуртай цагтаа мэдээлэл хийж чадна. Тэр ч байтугай өөрснийхөө буруутай этгээдүүдийг шийтгээд, нөхөр Сталин огт байхгүй хуйвалдааныг илрүүлж, ямар ч гэм буруугүй цэргийнхээ удирдлагыг хүйс тэмтэрсэн гээд даян дэлхийгээр нэг зарлаж мэднэ. Гитлер өөрийнхөө генералуудыг хөндөөгүйг бодолцвол энэ бүхэн бүр ч үнэмшилтэй болж таарна. Эдгээр баримт бичгийг хуурамчаар үйлдсэний баталгаа Гитлерийн гарт байгаа учраас түүгээр мань хүнд дарамт үзүүлбэл хожмын яриа хэлэлцээнд давуу талтай болчихно. Үгүй ээ, тэгж ярихгүй, Гитлер түүнийг ийм урхинд оруулж чадахгүй, түүнийг залилах гэж оролдож болохгүйг мань хүн Гитлерт нотлож өгнө, түүний хуурамч бичиггүйгээр болохдоо л нэг болно. Хуучин ч болоод ирсэн, одоо ч болно. Баримт бичиг үзүүлнэ гэдэг бол аюултай жишиг бий болгоно гэсэн үг. Түрүү түрүүчийн шүүн таслах хурал дээр баримт бичиг яагаад байгаагүй юм бэ? гэдэг асуулт гарна. Зөвлөлтийн ард түмэнд элдэв цаасны хэрэг байхгүй, гагцхүү хэргээ хүлээсэн баримт л хэрэгтэй гэж Фейхтвангерээр дамжуулан бүх дэлхийд зарласан атал одоо яагаад цаас гээд байх болов? гэсэн асуулт гарна. Яагаад гэвэл түрүүн цаас байгаагүй, одоо бол байна гэх үү? Тэгэх юм бол өнгөрсөн шүүх хурлууд, төдийгүй ирээдүйнхэд эргэлзээ төрүүлэх болно, ирээдүйн хурлууд баримт бичиг бас үзүүлэхгүй шүү дээ. Шүүн таслах ажиллагааны тодорхой арга боловсорч төлөвшчихөөд байна. Энэ арга зөв болохоо харуулсан. түүнээс татгалзахын учир юу билээ?

Өнгөрсөн шүүх хурлуудын туршлагаас үзвэл хилийн чанадтай холбоотой аливаа т о д о р х о й зүйлийг дурдах явдал аюултай. Копенгагены “Бристоль” зочид буудал гэж дурдсан чинь тийм буудал тэнд байхгүй болж таарсан. Пятаковыг Осло руу ниссэн гэж зарласан, гэтэл тэр үед Ослод ерөөсөө онгоц буудаггүй байсан болж таарсан.

Энэ хавтаст хэрэг ингээд байж байг. Хэрвээ Гитлер өөрийнхөө генералуудыг шүүхээр шийдвэл өөрөө энэ баримт бичгээ нийтлэнэ биз. Тэр үед нь бид Тухачевский болон түүний бүлгийнхний буруутайг нотлох шинэ нотолгоо, шинэ баталгаа болгоод, орчуулаад сониндоо тавьчихна.

Тавдугаар сарын 13-нд уг хавтаст хэргийг Москвад байсан Улс төрийн Товчооны Рузутакаас бусад бүх гишүүнд үзүүлжээ. Тэрээр Рузутагт итгэдэггүй учраас тэр. Ийм хавтастай материал байгаа тухай өөр хэн ч мэдэх ёсгүй, эдгээр баримтыг цэргийн зөвлөл, шүүх хурлын алин дээр ч гаргаж тавихгүй гэдгийг мань хүн урьдчилан анхааруулав. Яагаад? Яагаад гэвэл, эдгээр баримтыг гаргаж тавьснаар Франц, Англи хоёр Улаан Армийн эв нэгдэл, хүч чадалд итгэхээ больж, тэдэнтэй явуулж буй хэлэлцээн бидний байр суурь суларч мэднэ.

Улс төрийн Товчооны гишүүд нөхөр Сталины байр суурийг нэгэн дуугаар бүрэн дүүрэн дэмжив. Тухачевский болон түүний бүх санаа нэгтнүүдийг цэргийн шүүхэд шилжүүлж, буудан алах хэрэгтэй гэж тэд мөн нэгэн дуугаар шийдэцгээв. Тухачевскийн урвасныг илчилсэн баримт бичгийг нийтлэвэл Улаан Армид итгэх Франц, Английн итгэлийг сулруулна, харин урвасны учир Тухачевскийг буудан алвал итгэл сулрахгүй гэдэгт тэдний хэн нэг нь эргэлзсэн байж магадгүй. Гэхдээ хэн ч тийм эргэлзээгээ гаргаж хэлээгүй. Ер нь, тийм эргэлзээ хэнд ч төрөөгүй байж болно.

Сталин Товчооны гишүүдийг явуулсныхаа дараа улаан хавтсыг хувийнхаа нууцын шүүгээнд хийж цоожлоод, Тухачевскийг дуудаж ирүүлэхийг Поскребышевг тушаав.

Хэдэн үл таних хүн Варяд хуучин ч гэсэн шил нь бүтэн номын шүүгээ оруулж өгөөд, дараа нь Михаил Юрьевичийн өнгөрсөн удаа ярьсан дөрвөн том сагстай сэтгүүлүүдийг авчирч өгөв. “Мир искусства”, “Аполлон”, “Весы”, “Золотое руно” зэрэг сэтгүүл, Бенуа, Сомов, Добужинский, Бакст, Серов, Лансере, Остроумова-Лебедева, Врубель нарын сийлбэрийн цомогнууд, Ахматова, Гумилев, Городецкий, Кузьмин, Мендельштам зэрэг шинэчлэгч найрагчдын, Блок, Белый, Вячеслав Иванов, Федор Сологуб зэрэг оросын, Артюр Рембо, Малларие, Верлен зэрэг францын бэлгэдэгч найрагчдын шүлгийн түүврүүд байна.

Варя бүх ном, сэтгүүлээ шүүгээнд эвлүүлж байрлуулаад өрөөгөө цэвэрлэж янзалсны эцэст Софья Александровнагийн орж, буйдан дээр нь ойчих мэт гараа алдлан суулаа.

-Ёох, ядарч гүйцлээ.

-Юу болоов, Варюшенька, өнөөдөр чинь амралтын өдөр шүү дээ?

-Михаил Юрьевич надад баахан ном, сэтгүүл шүүгээтэй нь өгсөн юм, түүнийг эмхэлж янзлаад.

Софья Александровна түүн рүү гайхасхийн харав.

-Та яав, Софья Александровна, хачин хараад байх чинь?

-Михаил Юрьевич чамд номноосоо өгөө юү?.. Сашад бас ном бэлэглэсэн юм.

-Юу гэсэн үг вэ?

-Сашаг эргээд ирэхэд нь хэрэг болно гэж байна лээ.

-Тэгээд олон ном бэлэглэсэн үү?

-Тэр шүүгээнд хар л даа.

Варя шүүгээг нээлээ. “Academia” судрын хориод оноос хойшхи бүх ном байна. “Яруу найргийн асуудал” цувралаас Жирмунский, Томашевский, Эйхенбаум, Тынянов, Гуковский, Виноградов энэ тэр байна. Варя Виноградов, Тынянов хоёроос бусдыг уншаа ч үгүй, мэдэх ч үгүй аж. Утга зохиолын болон театрын зүтгэлтний цуврал дурсамж, Анри де Ренье, Жюль Ромен, Марсель Пруст, Гофман нарын зохиолуудын эмхтгэл, “Дэлхийн утга зохиолын эрдэнэсийн сан” цуврал гээд их гоё хийцтэй номнууд. Варя эдгээр номыг Михаил Юрьевичийнд харсан юм. Түүхийн номнууд хоёр тавиур болсон байна... мань хүн яагаад хамаг номоо тарааж өгөөд байна? Ямар учиртай, юу гээч юм бол? Баривчлах, нэгжихээс эмээж байгаа юм болов уу? Гэтэл номонд юуных нь хэрэг төвөг байх вэ дээ. Шаардлагатай заримаас нь “ардын дайсны” бичсэн өмнөх үг энэ тэрийг нь ураад авчихсаныг ч хэлэх үү. Энэ нэг л жигтэй, нэг л хачин юм даа.

-Михаил Юрьевич одоо гэртээ байгаа юу?

-Пальто нь өлгүүрт байна, байгаа болох нь.

Варя тэдний хаалгыг тогшив.

-За, ор, ор!

Михаил Юрьевич вандан дээр хувцастай хэвтэж байснаа өндийн, тавхайгаа хөлөөрөө тэмтэрч углаад, хавчдаг шилээ шүүгээн дээр хайв.

-Та аягүйрхээ юү?

-Үгүй ээ, үгүй, юу гэсэн үг вэ, зүгээр түр хажуулсан юм гээд босч, гэрийнхээ хүрмийг өмсөх гэж ханцуйг нь олж ядан нудчив.

түүнийг ийнхүү хувцаслаж цөхөж, шилээ олж ядаж байх зуур Варя өрөөг нь эргүүлдэн ажиглав. Ном чигжээтэй байдаг тавиурууд хоосорчихсон нь айл биш юм шиг болчихож.

Михаил Юрьевич ширээ рүүгээ суугаад, Варяг бас суу гэж дохив.

Варя буйдан сандалдаа сууснаа Михаил Юрьевич рүү эгцлэн харж,

-Танайд нэг юм болжээ дээ? гэж асуув.

-Та яагаад тэгж асууж байна?

-Михаил Юрьевич, нэг л юм болсон байна даа гэж Варя улам шаргуу өгүүлэв.

-Варенька минь, надад юу тохиох вэ дээ? Толгойдоо дэмий юм бүү хураа.

-Та яагаад номын сангаа тарааж өгөөд байгаа юм бэ? Сашад бас ном бэлэглэсэн байна.

-Саша францын хувьсгалын түүхийг сонирхдог, Софья Александровнагийн надад ярьснаар бол, цөллөгт байхдаа хүртэл тэр сэдвээр юу хэе бичсэн гэнэ лээ, их чадвартай хүү, тийм учраас л би түүхийн холбогдолтой номоо түүнд өгсөн юм. Уншиж байг, та ч гэсэн уншаарай, нэгэн цагт дурсах болно... Михаил Юрьевич гэж нэг гайхал өвгөн байж билээ, өөрөө ном бичиж яваагүй, харин бусдын бичсэнийг цуглуулдаг, тэгээд бидэнд үлдээсэн юм гээд л.

Варя босч, Михаил Юрьевич рүү бараг тулж очив.

-Та надад үнэнээ хэл, танд ямар нэг ноцтой эмгэг байгаа юм уу?

Цаадах нь толгой сэгсрэв.

-Үгүй чиш, ёстой юу ч байхгүй.

-Ажил дээр чинь элдэв юм болоо юу? Тооллоготой холбоотой зүйл үү?

Тэрээр зүүн мөрөө хавчисхийв, ер нь тэгдэг хүн.

-Одоо элдэв юмгүй хүн хаа байх вэ дээ, Варенька минь.

-Нээрэн, хэнээс ч асуусан бүгд л муу юм хэлэх болж, уур уцааргүй хүн ч гэж алга, цөм бие биенээ отно, бусдын зовлонг нэг нь ч тоож байгаа юм алга, бүр тавлаж бахаа хангахыг яана: “Өө, шоронд хийчихээ юу, хохь нь, хорлож дайсагнавал тэгдэг юм!” Барьж л байг, буудан алж л байг гэсэн царайтай, ээ мөн аймшигтай байна аа!

Михаил Юрьевич Варя руу ч харахгүй, бодол санаа нь өөр газар яваа мэт нэг л хачин,

-Харамсалтай нь хувьсгалын зорилго мартагдаж байна, хүчирхийлэл байсаар байгаа төдийгүй аллага хядлага болон хувирч, энэ тээрэм цадах ханах шинж алга хэмээн өгүүлэв.

Тэгснээ сая нэг Варя руу харц өргөж,

-Чи бид хоёрын яриа дан минийх болчихлоо. Өвгөчүүл чинь бурах дуртай байх юм.

-Михаил Юрьевич! Та битгий өөрийгөө өвгөн гэж бай л даа!

-Би юу ярьж байлаа? Ээ бас, мартамхай болж байна.

-Та аллага хядлаганы тээрэм цадах ханах шинж алга гэж хэлсэн.

-Өө, тийм, зүйтэй. Төгс хүслэнтэнгүүд алан хядах замаар бүтээн байгуулж болно гэж итгэдэг, үл бүтэх этгээдүүд, муухай амьтад үүнийг ашиглан, алан хядах үйлдэл явуулж, тэг тэгсээр тэдэндээ гар хүрч, хүйс тэмтрэн хөнөөж, уриа дуудлагыг нь өөрийн болгон өмчилж байна. Цусан дээр аз жаргалтай, шудрага нийгэм байгуулж болохгүй. За ингээд гүйцээ, Варенька минь. Харамсалтай нь, та бид ийм цаг үед амьдарч байна. Элдэв муу юм эндээс л үүдэлтэй, хэнийх их вэ, хэнийх бага вэ гэхээс биш бүгдэд нь байна.

-Хувьсгал хэрэгтэй байсан юм уу?

-Асуултыг тэгж тавьж болохгүй л дээ гээд Михаил Юрьевич зүүн мөрөө дахин хавчисхийв. - Хувьсгал бол ороо бусгаа үзэгдэл, өөрөө жолоодогчийг төрүүлнэ, тэд нар нь хувьсгалыг цаг тухайд нь эв мөрийн замд оруулж, цадиггүй явдлыг тас цохих ёстой. Жолоодогчид тэр бүрий энэ шаардлагын түвшинд байж чаддаггүй юм. Миний бодлоор бол Ленин олон зүйл дээр буруутай, хувьсгал хийх үеэс хорин гурван оны эх хүртэл манай улс наад зах нь найман сая хүнээ алдсан. Гэхдээ хүчирхийллийн замаар шинэ төр улсыг байгуулж болохгүй гэдгийг Ленин бүр хорин нэгэн онд олж харсан. Тэгээд хөгжлийн өөр зам мөрийг товлож тодорхойлсон. Гэтэл Ленин өөд болсон. Сталин гарч ирсэн.

Тэрээр чимээгүй болов. Михаил Юрьевич хэзээ ч ингэж илэн далангүй ярьж байгаагүй, заавал болгоомжилдог байсан. Нөгөө бид хоёр энүүхэндээ ярьж байна шүү, цааш нь хүнд хэлж болохгүй шүү энэ тэр гээд хаяагаа манаад байдаг нь ч алга, үнэхээр зүрхтэй ярьж байна. мань хүн юу болчихоо вэ?

Варягийн толгойд гэнэтхэн нэг санаа орж ирэв.

-Михаил Юрьевич, таны юу болоод байгааг би гадарлачих шиг боллоо. Та Москвагаас явах гэж байгаа юм уу?

Өвгөн дүлгэнэн түгдрэв.

-Нэг бодлын тийм гэх үү дээ.

-Би танд нэг нууцаа ярья, энэ тухай Софья Александровнагаас өөр хэн ч мэдэхгүй. Манай эгч Нинагийн багшилж байсан сургуульд шалгалтын комисс, районы намын хороо энэ тэр гээд одоогийн бас нэг улигт явдал эхэлсэн юм. Захирлыг нь баривчлаад авах нь тэр. Би яг тэр оройд нь эгчийгээ Алс Дорнод руу явуулчихсан, эгч маань тэгж мэнд үлдсэн. Тийм учраас таны явах гэж байгаа ч бас зөв. Гэхдээ би саваагүйтэж асуусан юм биш, ийм юмны тухай ярих ёсгүйг ойлгоно. Би тус болж чадах байх л гэж зүгээр бодсон юм. Та ганцаараа чемодан саваа эмхлэх хэцүү, би юм савлаж эмхлэхдээ сайн шүү. Таны галт тэрэгний тасалбарыг авсан ч болох байна. Бас чемодан савыг чинь би аваад гарна, тэгээд хоюулаа метрон дотор уулзана, эгч бид хоёр яг тэгсэн юм.

-Гялайлаа, Варенька, гялайлаа, ач тус больё гэж байгаа чинь их сайн байна. Миний өгүүлсэн сэтгүүлүүдийг харав уу? хэмээн Михаил Юрьевич ярианы сэдвийг өөрчлөв.

-Зарим нэгийг нь харсаан, мэдээж, цөмийг нь яаж амжихав.

-Үзэж хараарай, сайхан шүү, танд цаг их бий.

Хэрэвзаяа Тухачевский тавдугаар сарын 1-нд индэр рүү эргэж харсан бол, хэрэвзаяа мань хүн түүний нүүрийг тэгэхэд харсан бол, Тэрээр одоо түүнийг дуудуулахгүй ч байсан байж магадгүй.

Гэвч Тухачевский ч эргэж хараагүй, мань хүн ч түүний царайг хараагүй. Тухачевский түүнд шилээ харуулаад явчихсан. Гэтэл мань хүн алуурчин биш. мань хүн хүний нүүр рүү харахаас биш, шил рүү харахгүй. Тийм учраас мань хүн сүүлчийн удаа Тухачевскийн нүүр рүү харна: Цаадах нь хоногоо хүлээж байна уу, үгүй юу, үхэхээс өөр замгүйг ойлгож байна уу, үгүй юу, эсвэл юу ч гадарлаагүй явна уу? Ийнхүү сүүлчийн удаа харваас тэр хүн түүний хувьд байхгүйтэй адил болно. Үхтэл нь цагийн зай, өдрийн зай, долоо хоног эсвэл сарын зай байна уу, тэр хамаагүй.

мань хүн өөрөө хэзээ ч ял зарлаж үзээгүй. Харин ч болвоос өөрийнхөө тулгадаг ялыг нуун далдлана. Тэрээр хүнийг тайвшруулдаг аргатай. Заримдаа сонор сэрэмж алдуулах гэж тэгнэ. Харин Тухачевскийн хувьд бол ийм шалтаг байхгүй. Тэр нэгэнт аюулгүй болсон. Комиссариатад ажлаа хүлээлгэж өгч байгаа, долоо хоногийн дараа Куйбышев руу явна, түүнийг тэнд нь барьж авна. Тухачевский анги, нэгтгэлийн дарга нартай холбоо барьж байгаа тухай ямар ч мэдээ алга. Хилийн чанад руу зугтаах боломж байхгүй. түүний алхам бүр тодорхой. Цэргийн бүх нисэх буудал хяналтад байгаа. хэнтэй ч холбоо барьж чадахгүй, хаашаа ч оргож зугтахгүй.

Тэглээ ч гэсэн мань хүн түүнтэй уулзаж, нүд рүү нь харах ёстой, тэгж амь насыг нь хэлтрүүлэх горьдлого төрүүлэх ёстой. мань хүний дотор хаа нэгтээ санваартны сэтгэл үлдсэн байж мэднэ. Юу гэхэв... хүнд тэнгэрт хойт нас амласнаас, нартад аж төрөх найдвар төрүүлсэн нь эрхбиш нигүүлсэнгүй болой.

Үгүй ээ, мань хүн санваартан биш, нигүүлсэнгүй сэтгэл хөдлөж байгаа юм биш. Нигүүлсэнгүй сэтгэл бол улс төрийн ай биш, нигүүлсэнгүй сэтгэл бол аль нэг буяны нийгэмлэгийн авхай нарын амны уншлага. Тэрээр нэгэнт ялагдаад одоо хэр амь тавиагүй буй дайснаа өөрийн нүдээр харахыг хүсчээ. мань хүн нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс түүнд горьдлого төрүүлэх гэсэн бус, цаадах нь амьд үлдэх аливаа боломжноос зууралдан эцсээ хүртэл юу ч гадарлахгүй яваг гэсэндээ тэр. Зайлшгүй үхнэ гээд шийдчихсэн хүн бол хорвоогийн явдлаас нэгэнт хөндийрчих учраас түүнд нөлөөлөх боломж байхгүй, харин амьд үлдэнэ гэж өчүүхэн боловч горьдож байгаа хүнд бол эрхбиш нөлөөлж болно. Тухачевский эцсийн мөчөө хүртэл санаа зовж, түгшүүрлэж байг.

Тухачевский орж ирэв. Мэдэгдэм төдий мэхсхийгээд түүний заасан сандал дээр суулаа. Гэхдээ тэртэй тэргүй тэр сандал дээр суух гэж байсан царайлж, хэзээний өөртөө эрэмшсэн янз хэвээр байна.

Сурвалжит царайтай, ихэмсэг дүртэй, хөдлөж барихаасаа авахуулаад ноён зантай. Гэтэл Шапошниковыг харахгүй юу, ялгаагүй хааны армийн офицер, гэхдээ түүн шиг дэслэгч биш, хурандаа байсан хүн, ямар даруу төлөв аяг зантай билээ дээ, х э н т э й харьцаж байгаагаа

ойлгож байгаа нь тэр. Тухачевский шиг “иргэний дайны баатар” болох гэж зүтгэхгүй, Колчак, Деникин, Антоновыг ялсан гол хүн, Кронштадын бослогыг дарагчийн дүр эсгэхгүй, нөхөр Сталин Варшавыг эзлэхэд нь саад хийгээгүй бол бараг л дэлхийн хувьсгал хийчих байсан хүн болох гэж зүтгэхгүй.

-Таныг Куйбышев руу шилжүүлсэнд гомдоогүй биз? гэж Сталин асуув.

-Намайг хааш нь ч явуулсан би албаа гүйцэтгэхэд бэлэн байна, харин шилжүүлсний шалтгааныг би мэдэхгүй байгаа.

-Нөхөр Ворошилов танд хэлээгүй юү?

-Үгүй.

-Та яагаад түүнээс тайлбар шаардаагүй юм?

Тухачевский түүн рүү харав. Тэрхүү тайван хурц харцны угт тохуурхах янз буйг Сталин мэдрэв.

-Би тушаал биелүүлэх үүрэгтэй. Ажлаа хүлээлгэж өг гэж тушаасан, би тэр ёсоор өгч байгаа.

Сталин нүдээ дарж байснаа Тухачевский руу харав.

Намын зүгээс таны хувьд гомдол санал байхгүй. Нам танд итгэсээр ирсэн, одоо ч итгэж байна. Гэхдээ та улс орны байдлыг харж байна. Энэ бүхэн дотоод улс төрийн нөхцөл хурцадсантай холбоотой. Дайсагнагч этгээдийн эсэргүүцэл нэмэгдэж байна, нөгөөтэйгүүр зөвлөлтийн хүмүүсийн сонор сэрэмж ч дээшилсэн. Гэхдээ сонор сэрэмж дэндэх, хэтрэх явдал зөвлөлтийн хүмүүсийн дундаас гарч байна, тэгснээр эрүүл бус хардалт сэрдэлт газар авах талтай. Ийм үзэгдэл, харамсалтай нь, армид бас байна. Хэдийгээр манай хүмүүсийг ойлгож болох ч энэ бол тусгүй зүйл. Зиновьев-Каменев, Пятаков-Радекийг шүүн таслах ажиллагаанууд уур амьсгалыг ихээхэн халаасан шүү дээ. Ийм нөхцөл байдалд таны дотнын танил Юлия Ивановна Кузьмина баривчлагдсан байна...

Тэрээр чимээгүй болзнов.

-Юлия Ивановна бол Николай Иванович Кузьмины авгай, Кузьминыг та мэдэх байх, 1903 оноос намын гишүүн, Баруун Өмнөд фронтын хуучин комиссар, Аравдугаар их хурлын төлөөлөгч, бас Кронштадын бослогыг даралцагч. Ямар ч сөрөг хүчинд оролцож яваагүй...

-Бид нөхөр Кузьминыг мэднэ гэж Сталин түүний үгийг тасдав. -Нөхөр Кузьмины гавьяа зүтгэлийг намын Төв Хороо мэднэ. Баригдсан хүн бол Юлия Ивановна Кузьмина, дахин хэлэхэд, таны с а й н танил. Энэ тухайд элдэв яриа, бэртэгчин яриа, эмс хүүх-нүүдийн хов жив тархаж байна. Эдгээр яриа, эдгээр хов цуурхлыг таслан зогсоох хэрэгтэй. Бид манай цэргийн удирдлагын нэр хүндийг хамгаалахыг хүсч байна. Манай цэргийн удирдагчдын нэр хүнд бол армийн нэр хүнд. Тийм учраас Улс төрийн Товчоо таныг Куйбышевт шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн юм. Яриа, хов жив намжиг, ДЯАК Кузьминагийн учрыг олог, дашрамд

ХЭЛЭХЭД, таны туслахын учрыг бас олог, тэр бас баригдсан гээ биз дээ.

Тухачевский дуугарсангүй.

Сталин түүнийг хүлээлгүй үргэлжлүүлэв.

-Зиновьев, Пятаков энэ тэрийн хэрэгтэй холбогдон баригдсан корпус командлагч Путна, Примаков хоёр хачин мэдүүлэг өгч байгаа.

Тухачевский бас л дуугарсангүй.

-Би Путна, Примаков хоёрыг хуучин троцкийчуудтай холбоотой байсны учир дурдаж байгаа юм, тэр холбоогоо таслаагүй юм байна л даа. Энэ холбоо харилцаа арми дахь улс төрийн ерөнхий уур амьсгалыг, мэдээж, төвөгтэй болгож байгаа, гэхдээ танд биечлэн хамаа байхгүй. Тийм учраас, дахин хэлэхэд, Улс төрийн Товчоо элдэв зохиомол цуурхалыг зогсоох, цаашид гаргуулахгүй байх зорилгоор армийн дотор зарим холио сэлгээ хийх хэрэгтэй гэж үзсэн юм. Байдал хэвийн болмогц, дэмий балай яриа зогсмогц та Москвад буцаад ирэх юм. түүнээс гадна, хэдийгээр түр ч гэсэн, цэргийн дотор орж ажиллах нь таны шаардлагаар үйлдвэрлэж байгаа зэвсэг техникийг шалгаж үзэхэд танд ашигтай байж таарна гэж бодож байна. Нөхөр Тухачевский, та юу гэж бодож байна?

-Би намын тушаасан газар хаа ч байсан ажиллана.

Хариулахаас зайлсхийж байна.

-За тэгвэл сайн байна.

Сталин босч, ширээ тойрч ирээд Тухачевскийд гараа өгч,

-Танд амжилт хүсье гэв.

Тухачевский өсгий хавсран ёслол:

-Баярлалаа, нөхөр Сталин.

Тэгснээ сунжруулсхийн,

-Уулзатлаа баяртай гэж хэлэв.

Уулзана гэж найдахгүй буйгаа ойлгуулж байгаа нь тэр. Найдахгүй байгаа нь ч зөв.

Сталин Ежовт утасдаж, Примаков, Путна хоёрын хэргээ бүрэн хүлээсэн мэдүүлгийг арван тавнаас оройтуулахгүй өөрт нь өгөхийг тушаав.

Яг тэр шөнө Примаков, троцкийчууд Ворошиловыг Якираар солих санаатай байсан, Якир Троцкийн надад үл мэдэгдэх маш нууц даалгаврыг биелүүлж байж магадгүй гэсэн мэдүүлэг өгчээ.

Ежов энэ мэдүүлгийг уншаад галзуу мэт уурсав. Энэ муу үл бүтэх Примаков өөрийг нь залилж, хэргээ будлиулахыг санаархаж байна. “Троцкийн үл мэдэгдэх даалгавар” гэж юу гэсэн үг вэ?

Ежов мөрдөн байцаагч Авсеевичийг дуудаж ирүүлээд, онцгой хэлтсийн дарга Леплевскийн дэргэд нөгөө протоколыг Авсеевичийн нүүрэнд тулган сэгсчиж, ийм цаасыг бол жорлонд хаясан ч болно гэж хашгичин дүрэмдэв.

-“Троцкийн үл мэдэгдэх даалгавар” гэж юу юм бэ?! Би танаас орос хэлээр асууж байна. Примаковыг нааш нь авчир, би түүнтэй өөрөө ярилцана!

-Авчрах арга байхгүй. Примаков өрөөндөө а м а р ч б а й г а а.

-Путна хаа байна? гэж Ежов Леплевскийгээс асуув.

-Путнаг цагийн өмнө Бутыркийн шоронгийн эмнэлгээс авчирсан. Энд байгаа.

-Путнаг авчир! гэж Ежов түүнд тушаав.

Путнаг авчрав. Тэр их доройтжээ. Бутыркийн шорон Их Британи биш юм чинь аргагүй биз. Царай нь жигтэйхэн цонхийчихож. Дипломатч хүний жавхаа өвчсөн мэт оргүй арилж. Чих нь дэлдийгээд, төрөлхийн тариачин эр тэр л төрхөөрөө өөд болох нь.

Ежов Сталиныг дуурайн намуухан дуугаар,

-За, яах болж байна, ингээд булзаад байх уу? гэж асуув.

Путна дуугарсангүй.

-Ярих хүсэлгүй байх нь гэж Ежовыг хэлэнгүүт Авсеевич Путнагийн мөрнөөс зуурч авлаа. Тэрээр зодохыг үзүүлдэг, юуг, яаж хийхийг мэддэг эр.

Тэглээ ч гэсэн Путнатай бараг өглөөний зургаа хүртэл ноцолджээ.

Ежов сүүлдээ бүр харахаасаа залхаж, өөрөө ажилд оролцож эхэлжээ. Тамхиа дөнгөж асаагаад Путнагийн нүцгэн биен дээр нухаж унтраана. Бараг бүтэн хайрцаг тамхи үрж байж, муужрах шахсан Путнагаар Тухачевский, Якир, Фельдман гурав “зөвлөлтийн эсрэг троцкист цэргийн байгууллагын” гишүүн мөн гэсэн мэдүүлэгт гарын үсэг зуруулжээ.

Ежов зургаан цаг өнгөрч байхад албан тасалгаандаа эргэж ирж, давхар жижиг өрөөнийхөө буйдан дээр суузнав. Сталин одоо Кремльдээ эрт ирдэг болсон, арван хоёр аягүй бол арван нэгэн цагт хүрээд ирнэ, энэ үед Николай Иванович ажил дээрээ байж байх ёстой.

Ширээн дээр нь дарс, цагаан архи, коньяк, шинэхэн зууш бэлэн байна. Николай Иванович нэг хундага архи татаад давсалсан өргөст хэмхээр даруулав. Ээ бас, сайхан хэмх. Дахин нэг хундагалж уугаад, загасан талхны булангаас эмтэлж, цөцгийн тос түрхээд, дээр нь нэг халбага бажгир түрс шавж амтархав.

Сүүлийн хэд хоног Николай Иванович гэртээ харьсангүй. Хоёр, гуравхан долоо хоногт багтааж шүүх хурлыг бэлтгэх үүрэг авсан болохоор цаг үнэхээр давчуу, өдөржин шөнөжин байцаалт явуулна. Шүүх хурал хаалттай болно, тэгсэн ч гэсэн яллагдагсад хэргээ хүлээж мэдүүлэгтээ гарын үсгээ заавал зурсан байх ёстой. Хугацаа богинохон болохоор буухиачлах, үхэр хулганатай яс цоожны тасалгаанд хорих, өлсгөх, цангаах, нойр хулжаах, сэтгэлээр дарамтлах, төрөл төрөгсөдийг нь үгүй хийхээр айлгах мэтийн ердийн арга олигтой үр дүн өгөхгүй байв. Энэ мэт ердийн арга цаг шаардана, гэтэл дээрээс шахаад байгаа. Тэгэхээр онцгой а р г а хэрэглэхээс өөр яахав. Тэр тухайд зөвшөөрөл олж авсан. Николай Иванович энэ тухай нөхөр Сталинд тойруу замаар тун болгоомжтой, тун эвлэгхэн ойлгуулахад, Тэрээр түүн рүү ёозгүй муухай харж,

-Хийвэл бүү ай, айвал бүү хий хэмээжээ.

-Тийм ээ, тэгэлгүй яахав. Гэхдээ тэд нар цэргийн шүүхэд очно гэдгийг би бодолцож байна, тэгэхээр... хүнд харагдах царайтай очих ёстой. Долоо хэмжиж, нэг огтол гэдэг биз дээ...

-Харин заавал огтлоно шүү гэж Сталин үгийг тасдан өгүүлэв. -Энэ зүйр үгний гол үг нь “огтол”. Огтлох л гэж хэмжинэ шүү дээ, түүнээс биш хэмжих гэж огтлохгүй.

Энэ бол маш хатуу эрүү шүүлт тулгаж болно гэсэн тов тодорхой зөвшөөрөл.

-Тийм ээ, тийм хэмээн Николай Иванович сэтгэл уужран санаа алдав.

Тухачевский, Якир хоёр төдийгүй бусад нь ч гэсэн хуйвалдаанд оролцсоноо үгүйсгэж, тас зөрнө гэдгийн тухайд Ежовт эргэлзээ байсангүй. Тэгэхээр хамгийн хатуу ширүүн эрүү шүүлт тулгахаас өөр аргагүй болно. Жишээлбэл, “хараацай” хийнэ: муусайн нохойн гөлгийг түрүүлэг нь харуулж хэвтүүлээд, гар, хөлийг нь дор дор нь хүлнэ, тэгээд урт оосроор морь хазаарлах мэт амгаалаад хоёр үзүүрийг мөрөн дээгүүр нь гаргаж, хөлийг нь оосорлон шил рүү нь хүртэл татна, тэгээд нурууных нь үе нурхийх хүртэл нөгөө оосроо чангалаад байна. Эсвэл “фриновскийн эмээл”-д суулгана, Ежовын орлогчийн нэрээр нэрийдсэн шүүлт, уул нь нэг их ухаан зарсан эд биш: яллуулагчийг нүцгэн өгзөгөөр нь хоёр цахилгаан тулган дээр суулгаад түлэнхий мах ханхалтал нь барина. За, тэгээд гойдын зөрүүд гайхал таарвал, жишээ нь, түүний “төмсийг шахаж” болно. Шалдагнаж байгаад, шалан дээр гэдрэг нь харуулж хаяна, энэ шүүлтэд таван танхай эр оролцох ёстой, хоёр нь хөлийг нь алцайлгаад суучихна, хоёр нь гарыг нь чангаагаад суучихна, тавдахь нь савхин гутлаараа бэлэг эрхтнийг нь гишгэлж эхлэнэ. И й м ю м ы г тэсдэг хүн байхгүй! Гэхдээ аюул бас бий, яльгүй ихдүүлчихвэл нөгөө хүнийг шүүх хуралд аваачих аргагүй болно.

Түүнчлэн шүдэнзний галаар чихний үс шатаахдаа бас болгоомжтой хандах ёстой, эс тэгвэл чих нь цэврүүтнэ, толгойг нь боох хэрэг гарна, яаж тийм хүнийг шүүх хурлаар оруулахав. Нөгөөдүүл нь дэндүүлчих гээд байдаг учраас Николай Иванович тэр болгоныг биечлэн хянахаас өөр аргагүй болно. Тэгээд л албан тасалгаандаа хүртэл хонодог хэрэг.

Гэхдээ, тэгж яривал, Николай Иванович гэр рүүгээ нэг их тэмүүлээд байгаа юм биш. Гал голомт нь нэгэнт нурчихсан. Уул нь яаж мэрийж хичээж байж босгосон билээ, яаж өмгөөлж хамгаалж явлаа даа... Тэднийд хүүхэд гараагүй ч нэг охин өргөж авсан, Наташка, цагаан

толгойтой, өхөөрдөм хөөрхөн охин, жаахан байхдаа өглөө тэр хоёрын өвөрт орж ирээд, үнсэж үмхэлж, наалдаж нялуурч, сүйд болдог сон. Эдүгээ мань хүн гардан эцэг эхийг нь үгүй хийж буй хүүхдүүд ч гэсэн хүүхэд асрах газар баяр жаргалтай аж төрцгөөг. Өөр овгоор өсч өндийцгөөнө, тэгээд зөвлөлтийн жирийн иргэд шиг аж төрцгөөх болно. Гэтэл зарим хэсэг нь “ардын дайсны хүү буюу охин” гэсэн им тамга зүүж, эцэг эхийнхээ мөрөөр талийна. Тэднийг хүүхэд асрах газар очихоос “аварсан” тэнэг эцэг эхдээ л баярлах юм биз дээ, зайлуул. Товчдоо, хэний аз дайрахаас л шалтгаална. Наташкаг хүүхэд хуваарилах газраас олж авсан, аз гозойсон хэрэг. Гэтэл одоо гэр бүл нь нурж байгаа учраас тэр охины заяа төөрөг яах бол, бүү мэд...

Ежов ч өөрөө өргөмөл хүүхэд, жирийн ажилчин айлд өсч хүмүүжсэн, хар багаасаа хөлсний ажилд орж, арван долоон онд хорин хоёртойдоо намд элссэн. Ер нь ч ажилчин залуус бараг бүгдээрээ большевикуудыг дагасан. Меншевик, эсерийн араас айварлагчид, маргагчид, чойгогүй философичид, ялзарсан сэхээтнүүд авамхайлсан. Большевикуудыг ойлгож цөхөх юмгүй, бүх юм хялбархан тодорхой байсан. Орчлонг өөрснийх, хүнийх гэж хуваана. хүнийхийг устгах хэрэгтэй, өөрснийхнээ бараадах хэрэгтэй. Ганц сахилгатай: “тушаасан л бол биелүүл, бодох хэрэггүй, боддог хүмүүс нь бодчихсон байгаа”.

Намхан чацтай Николай Иванович индэр дээр байна уу, жагсаалд байна уу, олны дунд байна уу, хаа ч байсан одой хүн шиг харагдана. Хажууд нь буй хэн боловч түүн рүү дээрээс нь харна, ө н д ө р л ө г ө ө с харах ихэс мэт харна. Залуудаа сайхан дуулдаг, найзууд нь бурхнаас заяасан цээл хоолойтой гэдэг байсан, түүнийг Петроградын нэг профессор авгай сонжиж байсан удаатай. Ихэмсэг өлөгчин байж дээ! Дуулуулж үзчихээд, “Чи хоолойтой юм байна, гэхдээ сургууль алга, үүнийг залруулж болно. Харин залруулж болохгүй юм чиний чац байна, дуурьт тоглолоо гэхэд хоршин дуулагч ямар ч хүүхэн чамаас тохой өндөр байх юм байна. Уран сайханчаар дуулж яв, найрал дуучидтай дуулж яв, чиний байр ердөө тэр” гэж айлдсан.

мань хүн өөрийнхөө байрыг өөрөө олсон. түүний байр тайзан дээр биш, найрал дуучдын дунд бус, индэр дээр бус, харин намын аппаратад, бичгийн ширээний ард, түшмэлийн суудалд байжээ. Од гийсэн жинхэнэ байр нь энэ байж. мань хүн үүнийгээ яг олсон, гэхдээ яг цагаа олж олсон. Иргэний дайн дууссаны дараачаас чухамхүү суудал бүхнийг жолоодож эхэлсэн билээ. Суудалтай хүн эрх мэдэлтэй болж таарсан юм.

Тэрээр ажил дээрээ тогтвортой, махруу, олон таван үггүй, ойворгон зангүй учраас бүх хүний аянд таардаг бөгөөд, хэн нэгэнд нь наалдаж дагахгүй тул түүнийг бүгд өөрийн талын хүн гэж үзнэ. Хориод оны дунд гэхэд Казахстаны нэг мужийн намын дарга болчихсон байж. Николай Иванович албан хэрэг явуулах сталинч хатуу тогтолцоог талархана. Энэ тогтолцооны амин сүнс нь боловсон хүчинг, хэрэгтэй боловсон хүчинг, ө ө р и й н т а л ы н боловсон хүчинг зөв сонгон байршуулах явдал гэдгийг Тэрээр сайн ухаарчээ. Тэгээд удирдлагын суудлын төлөө намын дотоод тэмцэл төдөлгүй өрнөхөд Николай Иванович үг дуугүй Сталины талыг барьж, түүнийг эсэргүүцэгчдийг зайлуулж, талархагчдыг нь дэвшүүлж эхлэв. 1929 онд, хамтралжуулах хөдөлгөөн ид өрнөж, нударганчуудыг хиар цохиж байсан үед түүнийг Москвад шилжүүлэн авчирч, газар тариалангийн ардын комиссарын орлогчоор тавьжээ. мань хүн энд ирээд, сая сая хувийн аж ахуйтныг хамтралд оруулах, түм буман тариачдыг нүүлгэн шилжүүлэх тухай заавар дүрмийг боловсруулжээ. Авгай нь нэг удаа,

-хүн ард л хөөрхий байна гэж хэлсэн.

-Би хөөрхий биш байна уу, хэдэн хоногоор комиссариатаас гарахгүй байна шүү дээ?

Үнэхээр ч өнжин хонон ажиллаж, хамтралжуулалтын мэдээ сэлтийг муж мужаар нь төдийгүй, район районоор нь гарган, ТХ-нд нягт нямбай илтгэж байв. Энд нөхөр Сталин түүнийг анзаарснаар 1930 онд ТХ-нд шилжүүлж, боловсон хүчний хэлтсийн эрхлэгчээр тавьжээ. Тэрээр нөхөр Сталины удирдлага дор ажиллахдаа гайхалтай түргэн дэвшлээ: Улс төрийн Товчооны орлогч гишүүн, дотоод явдлын ардын комиссар, Пятаков-Радекийн хэргийг шүүн таслах ажиллагааг бэлтгэн хэрэгжүүлээд, цэргийнхнийг шүүх ажиллагааг бэлтгэж байна. Чухамдаа нам дотор хоёрдахь хүн. Одоо түүний байр суурийг хэн хүнгүй харцгааж байна. түүнд Товчооны гишүүд хүртэл нялганадаг болсон, хувь заяагаа зөгнөн мэдэрч буй хэрэг.

Яршигтай ажил. Гүйцэтгэх ажилтнууд л үүнийг хийх ёстой, гэтэл заримдаа, өнөөдөр Путнаг яасан шиг биечлэн туслах шаардлага гарах юм. Иргэний дайнд дайсан тодорхой байсан-хөрөнгөтөн, цагаантан хоёр, хамтралжуулах үед ч бас тодорхой-нударганчууд. Тэд нарын алианаар ч ямар нэг хэрэг хүлээлгэх шаардлага байгаагүй, шууд л цааш нь харуулчихна. Одоо бол тийм биш, одоо бол хүн нэг бүрчлэн бурууг нь нотлох ёстой, бүх юмыг номын дагуу бүрдүүлэх шаардлагатай. Ямар аргаар нотлох нь онц биш, гол нь протоколд гарын үсэг зурсан байх ёстой, тэгүүлэх арга ДЯАК-д хангалттай бий. Ийм ажил дээр бүр зэрлэгшиж гүйцэх юм. Наташкатай тоглон, жаахан ч болов амсхийж сэгхийдэг цорын ганц газар нь гэр нь байсан. Гэтэл одоо гэргүй боллоо.

мань хүн эхнэртэйгээ арван таван жил аж төрсөн, арван таван жил! Женя өөртэй нь үнэхээр хайр сэтгэлээр суусан, тэр үед мань хүн хэн байлаа даа? Жирийн нэгэн намын ажилтан байсан, гэхдээ хар үстэй, хархан нүдтэй ямар хөөрхөн амьтныг уургалсан гээч, харин одоо бол хөл нь хавагнаж, зүрх нь гэнэ гэнэ дүрсгүйтэх болж... Төлөв даруу. Боловсролтой. 1929 онд Москвад ирэнгүүтээ “Сельхозгиз”-д жирийн хянагчийн ажилд орсон. Бичиг үсэг сайн хүн л энэ ажлыг хийнэ гэж өөрт нь тайлбарлаж байсан удаатай. түүний дэмжлэг татаасгүй албан тушаал ахисаар “СССР на стройке” сэтгүүлийн ерөнхий эрхлэгчийн орлогч болтлоо дэвшсэн, хүмүүсийн яриагаар бол тун сайн ажилтан гэх.

Харин эхнэрийн хувьд муу авгай болж хувирсан. Ноднингийн есөн сараас, түүнийг дотоод явдлын ардын комиссар болсноос эхлээд гэр бүлийн доторхи харилцаа муудсан. Энэ томилолтыг шууд үгүйсгэсэн. Үүнээс өмнө түүнийг оройтож, өглөөний тав, зургаан цагт ч ирсэн, хоолоо идээгүй хүлээгээд сууж байдаг байсан, хажуулж зүүрмэглэсэн ч байсан заавал босч ирээд цугтаа хооллодог байсан. Гэтэл одоо гэрийн үйлчлэгч хоолыг нь өгдөг, авгай нь унтаж байдаг болсон. Өглөө эрт ажилдаа явах ёстой юм байх. Нэг удаа бүр тохуурхах маягтай, “Би ямар ардын комиссар биш, арав гэхэд редакци дээрээ байх ёстой...” гэж хэлсэн.

Ноднин эмэгтэйчүүдэд зориулж “Общественница” сэтгүүл бий болгосон. Женя тэр сэтгүүлийн редакцийн гишүүнээр томилогдсон. Редактороор нь Женягийн найз Ася Сергеевна Поповаг томилсон. Попова бол Сырцов-Ломиназегийн эвслийн удирдагч Сырцовын авгай. Тэрээр Поповагийн хувьд болгоомжтой байхыг Женяд захих гэтэл, “Бид хамт ажилладаг юм” гээд хавьтуулаагүй. За яахав, чимээгүй өнгөрсөн. Тэдний редакцийн нэг

ажилтны троцкист нөхөр баривчлагдсан, гэтэл Женя тэр хүүхнийг бүх редакцийнхаа нүүрэн дээр тэгэхээс тэгэх гэж өөрийнхөө машинд суулгасан гэж байгаа. мань хүн энэ тухай ч бас дуугүй өнгөрсөн. “Албаны яаралтай ажил гараад машинаа өгсөн юм” гэж хэлэхийг нь мэдэлгүй яахав. Тэнэг эм, алхам бүрийг нь түүнд илтгэж буйг гадарлахгүй юм. Евгения Ежовагийн нэр дурдагдаж буй, “Общественница” “СССР на стройке”, сэтгүүлүүдийн холбогдолтой аливаа мэдээг өөрт нь заавал танилцуулж бай гэж мань хүн тушаал буулгасан билээ. Тэгээд мэдээ ирсэн нь тэр: Женя т ү ү н и й машиныг бүхний нүүрэн дээр ардын дайсны эхнэрт өгсөн. Аппаратаар нэг хов жив тарна даа. ТХ-нд буй түүний дайснууд үүнийг яаж ашиглаж байх бол! Сайхан сэтгэлтэй хүн гэгдэх нь. Нөхөр нь хар яргачин, гэтэл авгай нь сахиус шиг амьтан байх юм гэнэ.

Эцэст нь, сүүлчийн мэдээлэл. Ежова ерөнхий эрхлэгч Урицкийтэй нууц амрагийн холбоотой тухай мэдээлэл. Энэ бол араас хутга шаасан гэсэн үг! Мэдээлэгч сайн эр байна, энэ тухай мэдээлэхээс айсангүй. Николай Ивановичийн толгойд урд өмнө элдэв нууц амрагийн тухай санаа даанч төрж байсангүй. хэнд халдаж буйгаа хүмүүс мэднэ биз дээ. Гэтэл тэр муу Урицкий гэдэг шаар түүнтэй шөргөөлцөхөөс үнэхээр айсангүй гэж үү? Ежовтой шүү дээ! Тэгвэл Ежов тэгтлээ аймшигтай биш, Ежовоос айхгүй байж болох нь ээ. За, гайгүй, харж л байя! Шоронд хийчихээр арай өөрөөр донгодох байлгүй. Урицкий зохиолч Леопольд Авербахын хамаатан, тэгэхээр Ягодын хамаатан байж таарна... Өс үү? Зориуд зохион байгуулав уу? Хаана уулзацгааж байна? Тэднийг зөвхөн редакцидаа хамт байхыг харсан гэсэн. Тэгээд юу гэж? Цаадах нь редактор, наадах нь орлогч нь юм чинь. Тэр хоёр цуг сууж ярилцахгүй яах болж байна?! Гэтэл Урицкийн тасалгааны мухарт яг энүүн шиг амралтын давхар өрөө бий, яг тэнд эрхлэцгээдэг байх нь... Урицкийн гэр бүлийнхэн түүнийг Ежоватай харьцаагаа тасал гэж гуйж ядсан тухай няцаагдашгүй баримт бий. Тэр яриаг далдуур сонсоод бичээд авчихсан байгаа. Урвалт, урвалт, урвалт!

Николай Иванович гуравдахиа хундагалан тогтоов. Женя нь үнэнч, илүү дутуу зангүй, халамжтай, хиргүй тунгалаг хүүхэн, энэ шившигт оронд, үгүйдээн, ганц шудрага хүн байна, тэр нь түүний авгай гэж мань хүн бахархаж явсан билээ. Гэтэл үгүй шүү, түүний гэрт хүртэл шудрага хүн алга. Бүгд адгийн шаарнууд, улс орон тэр чигээрээ адгийн шаарнууд! хэнийг ч барьсан-шаар! хэнийг ч алсан-шаар!

За яахав, барих ч болно, алах ч болно! Урицкий, Евгения Ежова хоёрын тухайд бол ингэж шийдье: Баригдсан Ягодын хамаатан бөгөөд холбоотон Урицкийг маргаашийн дотор баривчлана. Урицкийн удирдлагад ажиллаж байсан Евгения Ежоваг түүний хэргийг мөрдөж дуустал гэрийн хорионд оруулна. Яваандаа байдал тодорхой болно.

Ежов ийм шийдэл товлоод, дахин нэг хундага татаж, бажгир түрсээр даруулан, халуун савгай цайнаас аягалж хэд оочсоноо, хувцсаа тайлан унтахаар хэвтлээ.

Софья Александровна өдөр ажил руу нь утасдав. Варя Сашаг Москвад ирчихэж гэж бодонгуут зүрх зогсчих шиг болжээ. Софья Александровна яль шаль юмаар хэзээ ч утасддаггүй билээ.

Гэтэл дуу нь дуулахтай үгүйтэй үхээнц буйг үзвэл лав өөдтэй юм хэлэхгүй нь бололтой.

-Варя, би байна, ажлаасаа чөлөө аваад харь, гэр рүүгээ оч. Би танайд яваад очье гэж Софья Александровна хэлэв.

Тэгээд утсаа тавьчихлаа.

Сашад ямар нэг юм тохиолдоо юу?

Игорь Владимирович түүнд юу ч хэлэлгүй чөлөө өгөв. Юмаа хумьж далд хийчихээд трамвай руу гүйв. Гэртээ ирлээ. Таван минут орчмын дараа Софья Александровна ирж, буйдан дээр лагхийтэл суугаад, амьсгаагаа дарах гэж оролдов.

-Юу болсон бэ, Софья Александровна?

Софья Александровна халааснаасаа зүрхний эмээ гаргаж, хуруу нь салганан нэг ширхэг үрэл хэлэн дороо хийв.

-Би чиний явж байхыг цонхоор харчихаад баахан яарчихлаа.

Дахин чимээгүй байзнаснаа, санаа алдан харцаа өргөв.

-Варя, Михаил Юрьевич амиа хорлочихож.

-Юун амиа хорлолоо гэж?! Софья Александровна, та юу ярьж байна аа?

Михаил Юрьевичийг баривчилж магадгүй гэж Варя бодсон явдал бий, тийм учраас Нинаг яаж явуулснаа ярьж, өөрт нь туслах санаа хэлж байсан. Хэдхэн өдрийн өмнө тэр хоёр энэ тухай ярьж байсан, гэтэл гэнэтхэн “амиа хорлочихож!”

-Хэзээ тэр вэ? Яаж? Яагаад тэгэв?

Софья Александровна хариу дуугарсангүй, нүдээ дарав.

Варя орон дээрээс дэр авч буйдан дээр тавив.

-Хажуулзана, Софья Александровна.

-А-а, за... Тэгье. Шаахайгаа тайлна аа... Хөл хөөчихдөг юм.

-Битгий хүчтэй тонгой!

Варя явган сууж, шаахайг нь тайлж өгөөд Софья Александровнаг хэвтүүлэв.

-Варенька, ямар аймаар юм болсныг чи төсөөлж чадахгүй хэ-мээн Софья Александровна уухилав. -Миний бие өглөөнөөс л нэг аягүйрхээд байсан юм. Хаврын тэнгэрийг үл мэдэх биш, зүрхэнд нөлөөтэй... Чи минь уучилж үзээрэй.

-Юу гэсэн үг вэ, Софья Александровна, зүгээр хэвг, хэрвээ ярихад төвөгтэй байгаа бол битгий ярь, би танай байранд очоод юу болсныг мэдчихээд ирье.

-Үгүй, үгүй, тийшээ явж болохгүй, хэрэггүй, ердөө болохгүй хэмээн Софья Александровна бачимдан үглэв.

-За, явахаа больё, та л юу гэнэв тэгье, харин та л тайвширч үз.

Софья Александровна дэрэн дээр толгойгоо гэдийсхийн нүдээ анив.

-“Түргэн” дуудах юм уу?..

Софья Александровна урт амьсгаа авав.

-Үгүй ээ, хэрэггүй... Одоо зүгээр... Би суувал дээр байх.

-Яах нь вэ? Хэвтэж бай.

-Хэвтээгээрээ ярихад хэцүү байна.

Варя түүнийг дэмнэн суулгаж, дэрээ ард нь ивж өгөв.

-хүн харах юм биш, ёстой аймаар юм! гээд Софья Александровна дахин урт санаа алдав. - Миний бие өглөөнөөс нэг л төдгүй байсан юм, би түрүүн хэлсэн, зүрх шархираад болох биш.. Тэгтэл эрхлэгч маань, “Софья Александровна, та ер нь харь” гэж байна. Гэртээ ирсэн чинь Михаил Юрьевичийн пальто өлгүүрт байж бай-на. Хачин санагдаад явчихлаа, уул нь ажил дээрээ байх ёстой хүн шүү дээ. Бие нь муудаа юм болов уу? Үүд рүү нь очоод чагналаа, чимээ алга, тогшлоо, зөөлөн тогшсон юм, хариу алга, арай чанга тогшлоо, дахиад хариу байдаггүй. Тэгээд хаалгаар нь шагайлаа. Тэгсэн чинь, ээ бурхан минь, Варенька, ээ бурхан минь, тэр дүүжлээстэй харагдана... Дүүжлээстэй шүү, ойлгов уу. Толгой нь хажуу тийшээ унжчихаж. Миний айсан гэж, Варя, бушаахан хаалгыг нь хаачихаад хана налаад авлаа, юу юугүй ойчих нь ээ... Яадаг хэрэг вэ?! Яана аа?! Арай үхээгүй ч юм бил үү, гэтэл би түүнийг салгаж авч чадахгүй, хүч яаж хүрэхэв... Байранд өөр нэг ч хүн байдаггүй... Шатны тавцан руу маажигнаж очоод хажуугийн айлуудын хаалгыг балбалаа, орцныхоо байгаа бүх хүнийг бужигнуулж өглөө... түүнийг оосорноос нь салгалаа, Михаил Юрьевич өөд болчихож. “Түргэн тусламж”, цагдаа энэ тэр ирлээ, манайд орж, юу болсон, яасныг асууж байна, би үзсэн харснаа хэллээ, хэнийг дуудсан, хэн буулгасан гэхчилэн протокол хийж байна лээ... Дараа нь, Варя, бас өөр хэдэн хүн ирсэн.

Тэрээр шивэгнэж эхлэв.

-ДЯАК-ын улсууд ирсэн, яг ирсэн шүү, надад үнэмлэхээ үзүүлцгээсэн, тэр хэрэггүй л дээ, би тэднийг үнэмлэхтэй үнэмлэхгүй шууд таних юм чинь. За тэгсэн чинь зөвхөн үнэнийг ярих хэрэгтэй гэж тушаагаад асууж байна: Михаил Юрьевичийнд ямар хүмүүс ирдэг байсан бэ? хэн ч ирдэггүй, орь ганцаараа байсан хүн гэж хэллээ. Төрөл төрөгсөд нь? Дүү нь Рязаньд бий, ноднин зун ирж байсан. Хаяг нь? Би Сашад зориулж түүний хаягийг авсан байсан юм, гэхдээ, мэдэхгүй, хаягийг нь мэдэхгүй гэж хариуллаа. Тэгтэл, Варя, гол юм нь байх, танд юм уу, бусад хөршдөө элдэв бичиг цаас өгсөн үү? гэж асуусан. Ойлгоо биз, тийм учраас би чамайг ийм яаруу дуудсан юм. Ойлгохгүй байна уу? Чи яагаад ойлгохгүй байна вэ? Тэр чинь Саша та хоёрт ном бэлэглэсэн шүү дээ.

-Тэгээд юу гэж?

-Юуны чинь юу гэж, Варенька! Энэ тухай ярьж болно гэж үү? Тэгвэл цаадуул чинь хамаг шүүгээ савыг чинь онгичоод, хуудас дараалан шалгаж, яагаад чухам танд бэлэглэсэн, ямар зорилготой тэгэв, өөр хэнд өгсөн?.. гээд шалгаачихна. Номны тухай бүү дуугар, эс тэгвэл дуудаж хоргоогоод салахаа үзэхгүй.

-Тэд нар юу хайгаа юм бол, юун цаас вэ?

-Би мэдэхгүй, гэхдээ хүн амын тооллоготой холбоотой болов уу гэж бодож байна. мань хүн чинь ЦУНХУ-д энэ асуудлыг эрхэлдэг байсан, сүүлийн үед түүнд базаахгүй явдлууд болсон дог оо.

-Зөвхөн түүнд ч биш. Ер нь ЦУНХУ-гийнхан бүгд байх. Михаил Юрьевич надад ярьсан. хүн амын тооллогоор дээрээс шаардаж байснаас зургаан саяар дутуу тоо гарсан гэнэ лээ, би сая яг саналаа. Тэгэхээр Михаил Юрьевич хувиараа тооцоо хийсэн байж магадгүй, түүнийг нь хайж байх нь л дээ.

-Өрөөг нь лацадчихсан, Михаил Юрьевичийг шарил хадгалах газар руу аваад явсан. Рязань руу, дүүд нь хэл хүргэх хэрэгтэй гэж Софья Александровна хэлэв.

-Тэгэлгүй яахав. Надад хаягийг нь өгчих, би цахилгаан явуулчихъя.

-Сайн бодох хэрэгтэй, Варенька, хэн цахилгаан явуулсныг “тэд нар” сонирхож мэднэ шүү.

-Би нэрээ тавихгүй юм чинь. “Яаралтай ир, Михаил Юрьевич нас барсан... Эсвэл Михаил Юрьевичийн бие их муу байна...” Гарын үсэггүй явуулчихна.

-Байз, Варенька, нас барсан гэж бичиж болохгүй, тийм цахилгааныг холбоо хүлээж авахгүй, бичиг баримт нэхнэ, ямар ч байсан чиний паспортыг үзнэ, тэгээд овог, нэр, бүх юмыг чинь тэмдэглээд авна. Нөгөөтэйгүүр тийм цахилгаан эзэндээ очих эсэхийг бүү мэд. Хүргэж өгөхгүй байж мэднэ. Би өөр нэг санаа хэлье: Төв холбоон дээр очоод Рязань руу утасд, надад түүний ажил, гэрийн утас аль аль нь байгаа. Михаил Юрьевичийн ажлын газраас ярьж байна гэж хэл. Михаил Юрьевич нас барсан гэж хэл, яг тэгж шууд хэлнэ шүү, нас барсан, түргэн ир гэж хэлээд утсаа тасалчих... Хамгийн аюулгүй нь энэ... Евгений Юрьевич маргааш өглөө ирээд, өрөө лацтай учир “тийшээ” очно, цаадуул нь “Ахынхаа нас барсныг яаж мэдэв?” гэнэ.

Тэр, “Ажлынх нь газраас утасдсан” гэж хариулна. Харин ажил дээр нь болохоор хэн ч утасдаагүй болохыг тэр дор нь нотлоно, тийм учраас бид хэнд ч гай болохгүй.

-Ингэж их болгоомжлох хэрэг баймааргүй юм хэмээн Варя царайгаа үрчийлгэв.

-Хэрэгтэй, Варя, хэрэгтэй.

-Ах нь нас барсан гээд дүүд нь хэл хүргэчих эрх надад байхгүй гэж үү дээ? Төрөл төрөгсөд нь хамаатан садныхаа хүнийг оршуулж болохгүй байх нь уу?

-Болно, Варенька, чамд ч эрх бий, тэр тухай яриа алга. Харин хүн нас барсны төлөө өрөөг нь лацаддаггүй, хөршүүдийг нь байцаадаггүй юм... Гэтэл яаж байна, лацдаж байна, байцааж байна. Тийм учраас бид нөхцөл байдлыг бодолцохгүй бол горьгүй. Би юу гэж чамаар азыг чинь туршуулж байх вэ дээ.

-За, тэгвэл яахав хэмээн Варя зөвшөөрөв.

Тэрээр цуваа өмсөж, Евгений Юрьевичийн утасны дугаарыг цүнхэндээ хийснээ буцаж суув.

-Ямар золгүй хэрэг вэ, хөөрхий муу Михаил Юрьевич. Дахиад түүнийг хэзээ ч харахгүй гэж сэтгэлд нэг л бууж өгөхгүй байна!.. Танд ямар байна?

-Би ч ялгаагүй гээд Софья Александровна нулимсаа арчив.

-Та өнөөдөр харихгүй, эндээ хонох юм уу?

-Тэр нь дээр байх, Варюша. Хөл, үнэхээр, хөдлөхгүй байна...

Михаил Юрьевичийн шарилтай авсыг хүүр хадгалах газрын нэгэн жижиг өрөөнд байрлуулав. Шарилчин нүүр рүү нь цэцэг тавьж, хүзүүнд нь үлдсэн оосорны ормыг далдлав. Варя Софья Александровнаг сугадан шарил руу ойртууллаа. Нүдний шилгүй л болохоос талийгаач ахыгаа өвчсөн мэт адилхан Евгений Юрьевич тэр хоёр руу балмагдсан янзтай харав. Хөршийн Галя авгай иржээ. Михаил Юрьевичийн хойноос үнэнхүү гашуудан, “Номхон, сайн хүн байж билээ” хэмээн нулимс унагаж байна. ЦУНХУ-гаас харьцангуй залуу гурван хүн иржээ. Царайд нь гуниг хурсныг харваас Михаил Юрьевичийг хайрлан хүндэлдэг байсан нь илт, ер нь түүнийг хайрлахаас өөр аргагүй хүн. Михаил Юрьевичийг дотно таних өөр хүмүүс Москвад байгаа нь мэдээж, гэвч хаяг, утасны дугаартай тэмдэглэлийн дэвтрийг нь бусад бичиг баримтын хамт хураагаад авчихсан болохоор хэл хүргэж чадаагүй.

Уул нь нэг юм хэлмээр, үг ерөөл айлдмаар байдаг. Гэвч хэн ч юу ч хэлсэнгүй, ямар ч ерөөл айлдсангүй. Албаны хуурай үгний хэрэг байхгүй, жинхэнэ сэтгэлийн үгээ хэн хэлэх вэ дээ. Цөмөөрөө чимээгүй зогсон, Михаил Юрьевичтэй сэтгэл дотроо салах ёс хийцгээв. Евгений Юрьевич ажлын газрынхны хамт шарилаа гаргаж, машин дээр тавиад, бүгд тойрон сууцгааж хөдлөв. Ваганьковын оршуулгын газар хөдлөөд л хүрэхээр ойрхон юм чинь юу байхав. Очмогц авсны тагийг хадаж, нүх рүү нь хийлээ. Михаил Юрьевичийг эх дэлхийнхээ өдөн өлгий лүгээ адил зөөлөн хэвлийд амгалан нойрсохыг билгэдэн хүн болгон атга шороо

хаяцгаав. Булшчингууд хүрээ шүүрэн, яах ийхийн зуур ажлаа амжуулахуйд, шинэхэн овгор шороон дээр булшны дугаар, талийгаачийн нэр бүхий пайзыг хатгалаа. Шороо сайн дагтаршиж суусан хойно, хойтон жил хавтан тавьж, булшны хөшөөг ёсчлон босгоно.

Дараа нь ажлын газрын гурав ажил руугаа буцав. Гэр гэр рүүгээ ч юм уу, эсвэл хувийн ажлаа хөөцөлдөхөөр явсан ч байж магадгүй, бодвол, тэдэнд бүтэн өдрийн чөлөө өгсөн байлгүй.

Софья Александровна, Галя хоёр Арбат руу буцаж, Евгений Юрьевич өнөөдөр Рязаньд очсон байх ёстой хэмээн галт тэрэгний буудал руу явав. Михаил Юрьевичийн эд хогшлыг гурав хоногийн дараа ирж авах юм байж. Саша, Варя хоёрт орхисон номыг аваарай гэж Софья Александровна түүнд хэлсэн боловч, талийгаачийн сүүлчийн хүсэл зоригийг зөрчиж болохгүй хэмээн татгалзав.

Варя ганцаараа үлдээд аав, ээжийнхээ булш руу очив. Ойрд ийшээ ирээгүй, лав л бүтэн өвөл өнгөрчихөж. Эзгүй оршуулгын газар. Ноднингийн унасан навчийг энд тэнд бөөгнүүлсэн харагдана. Эхний нялх ногоо цухуйсан байна. Зарим нэг булшин дээр шинэ цэцэг суулгачихаж.

Тэрээр булшны чөлөөний явган замаар бодлогошрон гэлдрэв. Хувьсгалын өмнөх хуучин булшнууд хөшөөнөөс гадна бүгд загалмайтай. Энүүхэнд нь зэрэгцээд сүсэггүй хүмүүсийн шинэ булш ярайж байна. Хүмүүс яагаад сүсэг бишрэлээ ийм түргэн орхичихов оо? Өөрийг нь бурхангүй үзлээр хүмүүжүүлсэн, энэ бол ойлгомжтой, гэтэл сая сая хүн ард хэдэн зуун жилээр сүсэглэж, мөргөж ирсэн шүү дээ. Тийм атал сүсэг бишрэлээ хаячихсан. Амархан хаясныг яана. Коммунизмд дорхноо сүсэглэх нь тэр. Энэ сүсгийг ч бас ийм амархан хаячих өдөр ирэх юм болов уу? Үгүй ээ, хаяхгүй, ингэж мундаг шигтгэж зоож байгаа юм чинь, хүний тархи толгойг үеийн үед эзэмдэж таарна...

Варя хашааны гадна гарч үрсэлсэн цэцэг худалдаж аваад аав, ээжийнхээ булш руу буцаж ирэв. Аав, ээжийнх нь нэртэй чулуун хөшөө: “Сергей Иванович Иванов”, “Мария Петровна Иванова”. Тэднийг өөд болсноос хойш Нина тэр хоёр яаж шуу хүн боллоо? Нагац эгч нь ирдэг, зунд нь өөр дээрээ Козловт аваачдаг байсан, одоо хүртэл тэндээ бяцхан байшинтай, бас өөр хэд хэдэн холын хамаатан байсан, тэд нар нийлж байж л тэр хоёрыг өсгөж өндийлгөсөн. Бодвол, энэ булшны хайс, хөшөө энэ тэрийг бас мөнгө нийлүүлж л босгосон байх. Тэгтэл ч Нина арван дөрөвтэйгөөсөө мөнгө олж эхэлсэн. Саша комсомолын хороотой ярьж тохиролцсоны дагуу түүнийг пионерийн удирдагчийн цалинтай ажилд оруулсан. Саша, Саша...

Варя туужуур, алчуурт боосон тосгуур, жимсний чанамалын шил

зэргээ хөшөөний араар хадгалдаг юм. Булшны хавийг цэмбийтэл цэвэрлээд, алаг нүдэн, хонин нүдэн цэцгэсээ суулгаж, шилээрээ хэдэнтээ ус авчран услаж тордлоо. Нойтон алчуураар хөшөө, хайсаа арчиж зүлгэлээ. Хайс нь энд тэндгүй зэв идчихсэн байна, шинээр дахин будах хэрэгтэй болох нь. Явган сандал газар хэвтэж байгаад бүр үжирчихэж, бүрмөсөн солихоос өөр аргагүй.

Варя муу ч гэсэн тэр сандал дээр сууж, нүүрээ нар өөд харуулав. Эндээс явах хүсэл алга.

Явах, орох газар ч алга. Өөрөө хэнд хэрэгтэй юм бэ? Михаил Юрьевичид хэрэгтэй байсан, очих тоолонд нь яаж баярладаг билээ дээ, одоо Михаил Юрьевич байхгүй боллоо, Софья Александровнад, бас Сашад хэрэгтэй байсан, одоо Сашад түүний хэрэг байхгүй. Юу хийх вэ, яаж амьдрах вэ? Ер нь амьдрах хэрэг байна уу? Айдас, хүйдэс, худал хуурмагийн дунд ингэж амьдрах уу? Утга учиргүй, цээжилсэн үгээ тотъчилон давтаж, бос гэсэн газар босч, суу гэсэн газар сууж явах уу? Ингэж амьдраад явах уу, эсвэл Михаил Юрьевичийн жишээг дагах уу? түүний амийг авсан “тэднийг” Тэрээр хэзээ ч өршөөхгүй, хэзээ ч. Яагаад амиа хорлосныг нь Тэрээр маш сайн ойлгож байгаа, түүний “Нуухыг хүсэхгүй байна, нуух ч үгүй... Зургаан сая... Тэд юуны төлөө амь үрэгдэв?.. Үүнийг нууж болохгүй, ёс суртахуунгүй зүйл” гэж хэлж байсныг тодхон санаж байна.

Гэхдээ хүн үхнэ гэдэг дэндүү аймшигтай юм. Боож үхнэ, авсанд орно, дараа нь булшны нүхэнд хийлгэж, өтний хоол болно. Үгүй, больё, чи минь! Яасан аймаар, яасан аюумшигтай юм бэ! Варя эргэн тойрноо харвал хэн ч алга, амьтай голтой юм алга.

Эрэгтэй хүний нэгэн хэмийн дуу л анир үргээж байна. Есениний булш холгүй байх бөгөөд тэнд нэг хүн шүлэг уншиж байгаа нь тэр ажгуу. Варя Ваганьковын оршуулгын газар өвөл, зун, хавар, намар хэзээ ч ирсэн тэр булшны дэргэд байнга хөлтэй, Есениний шүлгийг байнга уншиж байдаг билээ. түүний номыг хориглодог ч, түүнийг нударганчуудын яруу найрагч хэмээдэг ч, түүнийг гутранги үзэлтэй гэж муулдаг ч түүнийг хайрлах түмний хайрыг ширгээж эс чаджээ.

Варя ингэж бодонгуут өөрөө сэргээд ирэв. Үгүй ээ, үхэх хүсэл түүнд алга, амьдрах хүсэл л байна. Саша руу очих хэрэгтэй. Софья Александровна хаягийг нь олж л таарна. Нээрэн, Саша руу очих хэрэгтэй, ичих сэтгэлээ давж, хуурамч омгоо дарья, учраа ололцье, хайр сэтгэлтэйгээ шууд хэлье.

Есениний шүлэг дахин сонсодсон боловч, Варя дахиад л үгийг нь ялгаж сонссонгүй. Тэрээр босч, Есениний булш руу зүглээд, хүрээгүй явтал шүлгийн үгс тодроод ирлээ:

Буцаад эцгийнхээ голомтод ирнэ л, би

Бусдын жаргалаар сэтгэлээ зогооно доо,

Харлан ногоорох үдшээр цонхон тус, би

Ханцуйгаараа боомилж нартыг орхино доо.

Ахимагдуу насны бөгтөр хүн ийн уншиж байгаа аж. Хажууд нь хоёр эмгэн, зузаан ноосон цамцтай нэг залуу байна.

Өвгөн бургас шөргөн хашаан дотроо

Өрөвч тэргүүнээ гудайн гашуудна даа.

Буруугаа наманчлаагүй хөвүүн намайг

Боорлох нохдын хуцаанд хөдөөлүүлнэ дээ.

Варя эргэж хаалга руу зүглэхэд шүлэг араас нь нэхэх мэт чихнээ өртлөө:

Нуурын мандалд туяан цацал өргөсөн

Суурин саран тэнгэрийн замаа солихгүй.

Хашааны ёроолд уйлах, бүжих хосолсон

Орос орон ч бас төрөл арилжихгүй.

Путнагийн мэдүүлгийг яг арван нэгэн цагт Сталины ширээн дээр авчирч тавьжээ.

-Ингээд л гүйцээ юу?! гэхээс өөр юм Сталин хэлсэнгүй.

-Нөхөр Сталин, би таныг ойлголоо. Шалавлах болно. Уучлаарай.

Тавдугаар сарын 14-нд шилжих шөнө дэд зэргийн армийн командлагч, Фрунзын нэрэмжит цэргийн академийн дарга Август Коркийг баривчилжээ. Хааны армийн дэд хурандаа явсан, тавин настай армийн командлагч Ежовын тооцоолсноор амархан нугарах ёстой байтал, хоёр өдөр байцаагаад ямар ч үр дүн гарсангүй гэж Леплевский илтгэв. Корк зөрүүдлээд, бүх юмыг үгүйсгээд байж.

-Өөрийгөө нөгөө л Перекопын баатар гэж эндүүрээд байгаа юм. Тэр мууд онцгой ангиллаар эрүү шүүлт тулга! гэж Ежов тушаалаа.

“Онцгой ангиллын” эрүү шүүлт тулгасны дараа Ежовын нэр дээр бичсэн Коркийн хоёр өргөдөлд Сталины сэтгэл бүрэн ханана гэж ардын комиссар боджээ. Тэдгээр өргөдөлд өөрийг нь Енукизе троцкист цэргийн бүлэглэлтэй холбож өгсөн гэдгийг Корк хүлээжээ. Тэр бүлэглэл Кремльд цэргийн эргэлт хийх зорилготой байсан бөгөөд тэр үүднээс Тухачевский, Корк, Путна нарын бүрэлдүүнтэй эргэлтийн штаб байгуулсан хэмээж.

Тавдугаар сарын 15-нд корпус командлагч Фельдманыг баривчилжээ. Нөгөө аргаа хэрэглэснээр түүнээс дөч гаруй хүний талаар мэдүүлэг албадан авчээ.

Ежов эдгээр мэдүүлгийг Сталин, Молотов, Ворошилов, Каганович дөрөвг үзүүлээд, дурдагдсан бүх хүнийг баривчлах зөвшөөрөл шалсаар байж гаргуулж авав.

Ежов тавдугаар сарын 20-нд Примаковыг дахин шуурхай байцаах тушаал Леплевскийд өглөө. Леплевскийн хэлснээр Примаков ч шинээр байцаагдахад б э л э н болсон аж. Өнгөрсөн долоо хоногийн турш Примаковыг ганц минут ч нүдний хор гаргуулахгүйн тулд ДЯАК-ын ажилтан Бударев түүний өрөөнд цуг хонож байсан бөгөөд өдөр тэр үүргийг харгалзагчид гүйцэтгэж байжээ.

Примаковын мэдүүлэг нэн чухал учраас Ежов оройн арван цаг гэхэд Лефортовын шоронд өөрөө биечлэн очив. Авсеевич нойргүй зовсон Примаковыг Ежов, Леплевский хоёрын сууж байгаа өрөө рүү чирч гулдчин оруулж ирлээ. Авсеевич сая бас түүнтэй бараг таван цаг ноцолдсон юм байна, цэрэг цамцных нь нуруу шал нойтон харагдана. Гэвч муу хүний адаг Примаков ярдагласан хэвээр.

Тийм учраас Ежов,

-Манай энэ чинь морин цэрэг, Улаан казакуудын командлагч. Том дарга. Тэгэхээр онцгой ангиллаар үзэх хэрэгтэй... гэжээ.

Тэгээд өөрөө морь харахаар гарав.

түүнийг буцаж ирэхэд Примаков шуухитнан, Троцкийтэй холбоо сүлбээ бүхий Тухачевский хуйвалдааныг толгойлж байгаа гэж яг мэдүүлж таарчээ. Леплевский үүнийг тэр даруй протоколд тэмдэглэв. Примаков Тухачевскийгээс гадна Шапошников, С. С. Каменев, Гамарник, Дыбенко нарын цэргийн дөчин жанжныг нэрлэжээ. Ворошилов батлан хамгаалахын ардын комиссар байж чадахгүй гэж цэргийнхний дунд ярьдаг нийтээр мэдэх яриа мэдүүлгийн шинэ протоколд Ворошиловыг цэргийнхэн алахаар бэлтгэж байсан яриа мэтээр оржээ.

Сталин Примаковын мэдүүлгийг гардан үзээд, тавдугаар сарын 21-нд Ежовыг түүнийг орлогч Фринновскийн хамт хүлээж авав.

-Тухачевский Москвад л байна уу? гэж Сталин асуув.

-Маргааш Куйбышевт очно гэж Ежов товч хариулав.

-Яг тэнд нь барих хэрэгтэй гэж Сталин тушаав.

Тухачевский тавдугаар сарын 22-нд Куйбышевт, алба хаах шинэ газраа ирэнгүүт, Волгийн цэргийн тойргийн намын бага хурал руу явжээ. Хурлын дараа түүнийг мужийн намын хорооны дарга Постышев дээр ороод гарахыг хүссэн байна. Мужийн намын хороон дээр түүнийг баривчилж, Москва руу илгээжээ.

Хамгийн шалгарсан арга тус болоогүй учир Ежов Тухачевскийг өөртөө авлаа. Гэхдээ Леплевскийг байнга байлцуулахаар шийдсэн төдийгүй, Авсеевичийг гар чанга, авир ширүүн, бас дээгүүр цолтой Ушаковоор сольжээ.

Дөрвөн булиа залуу Тухачевскийг түүн рүү оруулж ирэв. Ежов тэднийг гаргасангүй.

Тухачевскийн нүүрэнд зодуулсны ул мөр алга. Ежовын тушаалаар түүний нүүрэнд шарх сорви гаргахгүйн тулд резинэн бороохойгоор балбаж, нүд рүү нь нулимж, нүүр рүү нь шээж доромжилсон аж.

-За, яаж байна, иргэн Тухачевский, та троцкийчуудын цэргийн алан хядах байгууллагад байдгаа хүлээн зөвшөөрч байна уу?

Тухачевский түүнийг жигшин харав.

Чингэвээс Ежов мухрынхаа өрөөнд өөрөө бодож олсон эцсийн аргаа хэрэглэх тушаал буулгав.

Сайхан эрийн яаж атиралдахыг харцгаая...

-Наадахаа больцгоо хэмээн Тухачевский ёолов. -Би гарын үсгээ зуръя.

Тухачевскийн гарын үсэгтэй мэдүүлгийг Ежов маргааш нь Сталинд өгчээ.

Гэвч нөхөр Сталин тэр өдрөө уг мэдүүлэгтэй танилцаж амжсангүй. Тэрээр Москвагаас Хойт туйлын дээгүүр буухгүй нисч АНУ орохоор зэхэж буй нислэгийн талаар Чкалов, Байдуков, Беляков нартай ярилцсан юм байж. Нөхөр Сталин энэ нислэгийг зургадугаар сарын хорьдоор хэрэгжүүлэхээр товложээ. түүний тооцоогоор бол Тухачевский болон цэргийн бусад жанжинг арван-арван тавны хооронд буудан ална, тэгэнгүүт үүнийг сайшаасан хурал цуглаан орон даяар болно, тэгээд яг араас нь залгаад хүн төрөлхтний түүхэнд хэзээ ч байгаагүй хосгүй нислэг үйлдсэний учир нийт ард түмэн магнай хагарам баяр хөөр болно. Ингэж хийх нь зөв. Дайсныг хүйс тэмтрэн устгаснаар Зөвлөлт Холбоот Улс улам хүчирхэгжиж, түүний олон улсын нэр хүнд дээшлэж буйг ард түмэн харах болно. Зөвлөлтөд зохион бүтээсэн АНТ-25 онгоцоор нислэг үйлдэнэ, энэ бол эрэлхэг, баатарлаг үйл хэрэг. Зөвлөлтийн яруу алдарт нисгэгч нар буултгүй алсын нислэгээр дэлхийн дээд амжилт тогтоож хорин мянган километрээс илүү зам туулна. Сталин Чкаловын тайлбарлаж ярихыг сонсонгоо, нарийн ширийн зүйлийг нэгд нэгэнгүй тодотгон лавлаж байв.

Тавдугаар сарын 28-нд Сталин Ежов, Фриновский хоёрыг Кремльд дуудан ирүүлж, Тухачевскийн мэдүүлэг хангалтгүй болсныг мэдэгдээд, нэмэх шаардлагатай зүйлийг хэлж өгөв: “Намайг бүр 1928 онд Енукизе баруунтны байгууллагад татан оруулсан. 1934 онд би өөрөө биечлэн Бухаринтай холбоо барьсан, 1935 оноос би германыхантай тагнуулын холбоо тогтоосон... Намайг 1936 онд Лондон явахад Путьна зохион байгуулж Седовтой (Троцкийн хүү) уул-зуулсан... Хуйвалдааны талаар би Фельдман, С.С.Каменев, Якир, Эйдеман, Енукизе, Бухарин, Карахан, Пятаков, И.Н.Смирнов, Ягода, Осипян болон бусад хүнтэй холбоотой байсан”.

Ежов тавдугаар сарын 29-нд Тухачевскийг дахин байцаахаар дуудуулав. Фринновский, Леплевский, Ушаков, нөгөө дөрвөн залуу энэ тэр хамт байлцав. Тухачевскийг дахин эрүүдэж, нэвширтэл нүдүүлж, цус нөжиндөө хутгалдсан түүнийг ширээ рүү шахаж байж, Сталины хэлж өгсөн мэдүүлэгт албадан гарын үсэг зурууллаа.

Энэ байцаалтын протоколыг Ежов Сталинд аваачиж өглөө.

Сталин түүнийг анхааралтай унших зуур хоёр ч газар цаас хавчуулж, уншиж дууссанахаа дараа нөгөө тэмдэглэсэн хуудсаа дахин сайтар ажигласнаа, ширээн дээгүүр Ежовт өгч,

-Энэ юу гээч вэ? гэж асуув.

Тэр хоёр хуудсан дээр хар хүрэн толбо байжээ. Зарим нь анхаарлын тэмдэгний дүрстэй.

Ежов ёстой сандарч гүйцэв. Цусны толбо үлдсэнийг харсангүй. Леплевский ч харсангүй, Ушаков ч харсангүй.

-Энэ бол цус, нөхөр Сталин. Мөрдөгдөгч протоколд гарын үсгээ зурах үед хамраас нь цус дусчихаж. Мөрдөн байцаагч шинэчлэн бичсэнгүй, уучлаарай.

-Та хаашаа харж байсан хүн бэ?

-Яагаад ч юм анзаарсангүй, нөхөр Сталин, уучлаарай. Ийм тохиолдол байх. Харин одоо

протоколыг шинэчлэн бичихэд их төвөгтэй. Энэ толбонуудыг бид химийн аргаар арилгана аа.

-Цэвэр бус ажилласан байна. Балиар ажилласан байна, цаашид нямбай байх хэрэгтэй хэмээн Сталин хөмсөг зангидав.

Тавдугаар сарын 22-нд Тухачевскийтэй нэгэн зэрэг ЗСБНХУ-ын Осовиахимийн дарга, корпус командлагч Эйдеманыг баривчилжээ. Маргааш нь түүнийг Лефортонад авчирч, Леплевскийн даалгасан ёсоор Карпейский, Дергачев хоёр байцаахаар болов. Эйдеман хуйвалдаанд оролцсон гэдгийг тас үгүйсгэжээ. Гэвч байцаалтан дээр орж ирсэн хэлтсийн орлогч дарга Агас түүний “чихийг нь цэвэрлэх”-ийг зөвлөсөн аж. Тэрээр “бид таныг яриулж чадна шүү” гэж занажээ. Тэгээд Леплевскийтэй нийлж хэд байцаасны дараа Эйдеман бараг элий балай болж, тавдугаар сарын 25-нд гар нь салганан байж, өч төчнөөн алдаатай өргөдөл Ежовын нэр дээр бичиж, “мөрдлөгт туслахад” бэлэн гэдгээ илэрхийлэв.

Тавдугаар сарын 28-нд Ежов Улаан Армийн Их бууны хэрэг эрхлэх газрын хорин найман ажилтны нэрийг Ворошиловт танилцуулав. Тэр жагсаалтын хажууд Ворошилов, “Нөх. Ежовт. Шаарнуудыг цөмийг нь барь. 1937.5.28. Ворошилов” гэж цохжээ.

Мөн тэр өдөр, тавдугаар сарын 28-нд Ворошилов арми командлагч Якирт утасдаж, цэргийн зөвлөлийн ээлжит бус хуралтай учир Москвад яаралтай ир гэж тушаажээ. Якир онгоцоор очиж болох байна гэж хариултал Ворошилов зөвхөн галт тэргээр ир гэж тушаав. Галт тэрэгний буудал дээр ДЯАК-ын дөрвөн ажилтан вагонд орж түүнийг баривчилжээ.

Тавдугаар сарын 29-нд тэргүүн зэргийн арми командлагч Уборевичийг баривчлав. түүнийг яг Якир шиг Москва руу дуудаж ирүүлээд, галт тэрэгний буудал дээр барьжээ.

Корк Уборевичийг баруунтны троцкист байгууллагад ордог гэж мэдүүлсэн бөгөөд барьсныхаа маргааш түүнийг Корктой нүүрэлдүүлэв.

-Эрс үгүйсгэж байна, энэ бол эхнээсээ аваад адгаа хүртэл худлаа гэж Уборевич өчжээ. -Би хувьсгалын эсэргүү байгууллагын тухай Корктой хэзээ ч, юу ч ярьж байгаагүй.

Леплевский тэр даруй Уборевичийг Лефортонад аваачиж, шаардлагатай мэдүүлэг гаргуулах тушаал Ушаковт өглөө. Хэдэн шөнө эрүүдэн шүүлгэсний эцэст Уборевич цэргийн хуйвалдаанд оролцсоноо хүлээжээ.

Ийнхүү шүүхээр оруулахаар товлосон бүх цэргийнхнээс мэдүүлэг гаргуулж авчээ.

Мөн тэр өдөр, тавдугаар сарын 30-нд Улс төрийн Товчоо, “Цэргийн фашист хуйвалдаанд оролцсоны учир намаас хөөгдсөн Якиртай холбоотойг харгалзан нөхөр Гамарникийг батлан хамгаалахын ардын комиссарын орлогчийн албан тушаалаас зайлуулах” шийдвэр гаргав.

Гамарник бие муу, хэвтэрт байжээ.

Тавдугаар сарын 31-нд түүний орлогч Булин, хэрэг эрхлэх газрын дарга Смородинов хоёр тэднийд ирж, Гамарникийг армиас халсан тушаалыг сонсгожээ. Тэр хоёр гараад машиндаа

хүрч амжаагүй явтал буун дуу гарч. Гамарник амиа хорлосон нь тэр.

Энэ тухай яг дараа өдрийнх нь “Правда” болон бусад сонин мэдээлэв: “БХКН-ын ТХ-ны гишүүн байсан Гамарник зөвлөлтийн эсрэг этгээдүүдтэй тогтоосон холбоо сүлбээндээ орооцолдож, илчлэгдэхээс илт айсандаа тавдугаар сарын 31-нд амиа хорложээ”.

Сталин хуанлийнхаа тавдугаар сарын сүүлчийн хуудсыг тасдлаа. Бүх юм дуусах нь энэ. Армийн толгойг егүүтгэлээ, бусад нь гар хөлийн үзүүрийн ажил, Вышинский, Ульрих хоёр янзалчихна. Харин Тухачевский болон түүний бүлгийнхнийг өөрсөд шиг нь марша-лууд, арми, корпус командлагч нар шүүнэ. Цэргийнхнийг мань хүн шүүж буй бус, цэргийнхэн өөрсдийнхөө доторхи урвагчид, тэрслэгчдийг устгаж буйг ард түмэн харах ёстой.

Сталин Ворошиловг утасдаж үүрэг өгөв: Маргааш зургадугаар сарын 1-нд багтааж батлан хамгаалахын ардын комиссарын дэргэдэх цэргийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааныг Улс төрийн Товчооны гишүүдийг оролцуулан хийлгэж, тэр хурал дээр ажилчин-тариачны Улаан Армид гарсан хувьсгалын эсэргүү хуйвалдааны тухай илтгэл тавь. Цэргийн зөвлөлийн хуралдаанд батлан хамгаалахын ардын комиссариатын бүх удирдах ажилтан, цэргийн тойргуудын бүх удирдлага, төрөл цэргийн бүх командлагч нарыг урьж суулга.

-Ежовтой ярилц, илтгэлийн үндэс болох гол материалыг чамд авчирч өгөг. Чиний илтгэлийн өмнө Ежов яллагдагсадын мэдүүлгийг цэргийн зөвлөлийн гишүүдэд танилцуулна гэж Сталин төгсгөлд нь нэмж хэлэв.

Тэрээр утсаа тавьж, сандлынхаа түшлэгийг налав. Зургадугаар сарын эхний арав хоногт багтааж дуусгах хэрэгтэй. Тавдугаар сар амжилттай өнгөрлөө, хөтөлбөр биеллээ, өнөөдөр амарсан ч болно.

Тавдугаар сарын 31-ны орой нөхөр Сталин, Улс төрийн Товчооны бусад гишүүний хамт Их театрт Узбекийн урлагийн арав хоногийн нээлтэд оролцов. Тэрээр засгийн газрынхны суудалд инээмсэглэн морилж, тайз руу харахгүй алга ташиж байв. Жолоодогчийнхоо ийм сайхан зантай байхыг журмын нөхөд нь ойрын найр үзээгүй болой.

Зургадугаар сарын 1-нд Кремльд хуралдсан цэргийн зөвлөлийн хуралдаанд төв аппаратын болон цэргийн тойргуудаас ирсэн 116 хүн оролцов. Цэргийн зөвлөлийн хорин гишүүн нэгэнт баривчлагдаад байгаа билээ. Хурлын уур амьсгалыг ярих юм биш. Хуралдааны эхэнд “цэргийн фашист хуйвалдаанд” оролцогчдын мэдүүлгийг сонсгов. Дэндүү нуршуу, залхам удаан уншлага болов. Хүлээсэн хэрэг нь хүн үнэмших аргагүй гэлтэй.

Ворошилов илтгэл тавилаа. Цэргийн зөвлөлийн гишүүдийн нэгэнт мэдэж буй ялт хэргийг давган ярьсны эцэст ингэж хэлэв:

-Тухачевский, Якир, Уборевич болон бусад нэлээд хэдэн хүн хоорондоо ойр дотно байсныг бид мэднэ, энэ бол нууц зүйл байгаагүй. Гэхдээ ойр дотно, зүгээр ч үгүй, бүлгээрээ ойр дотно байлаа гээд хувьсгалын эсэргүү болтол их хол...

Сталин нүдээ таглан сууж байна... Клим хэлэх үгээ олохгүй, нэг юм л хэвээд байна... Дөнгөж гуравхан сарын өмнө ТХ-ны Бүгд хурал дээр армид бүх юм сайн сайхан байгаа, хорлон сүйтгэгчид байхгүй гээд сайрхаад байсан. Манай эрхэм нөхөр Ворошилов хэт амирлангуй аяглаж байж дээ, одоо харахгүй юу, тагнуулын бүлэг сүвээнд нь үүрлэчихсэн байж...

-Өнгөрсөн жил таван сард Тухачевский манай гэрт, нөхөр Сталин, Молотов болон бусад олон нөхдийн нүүрэн дээр Буденный бид хоёрыг буруутгаж, намайг хэдхэн хүнээр өөрийгөө хүрээлүүлж, тэд нартайгаа бодлогыг хөтлөж, чиглүүлж байна гэх мэтээр ярьсан хэмээн Ворошилов үргэлжлүүлэв. -Тухачевский бүх хэлсэн үгнээсээ дараа өдөр нь няцсан... Тэгээд нөхөр Сталин өөр хоорондоо толхилцдогоо болих хэрэгтэй, Товчооны хурал хийж, юу болоод байгааг тодорхой авч хэлэлцэх хэрэгтэй гэж хэлсэн. Тэгээд энэ бүх асуудлыг бид тэр хурлаар хэлэлцсэн, гэтэл нөгөө хуучин дүн чинь эргээд л гарсан...

-Тэр чинь буруутгасан үгээ буцааж авсан шүү дээ гэж Сталин тэвчилгүй түүний үгийг тасдав. Ворошиловын бурахыг сонсох арга алга. Үхтлээ айчихаад, Тухачевский тэр хоёр хэзээний зөрчилтэй байсан гэж цохож хэлэх гээд байна, хуйвалдаанаас өөрийгөө салгаж авах гээд байна. түүнийг ямар нэг юмаар буруутгаж байгаа хүн байхгүй шүү дээ.

Ворошилов Сталин дурамжхан байгааг мэдэрч, Тухачевский тэр хоёрын харилцааны тухай биш, Тухачевский, түүний хань хамсаатнуудын ялт хэргийн тухай ярих ёстойг ойлгосон байж магадгүй, гэвч өөрийнхөө бодлоос салж чадсангүй, ёстой тархи нь ширгэсэн мулгуу толгой!

-Тийм ээ, буцааж авсан гэж Тэрээр Сталины хэлснийг нотлов. -Гэхдээ тэр хурал дээр Якир, Уборевичийн бүлэглэл миний тухайд их түрэмгийлж байсан. Уборевич хараахан дуугараагүй, харин Гамарник, Якир хоёр миний хувьд тун ёозгүй зан гаргасан...

Сталин сандлаа тар түрхийлгэн босч, цэргийн хамгийн том жанжнуудын сууж байгаа урт ширээг нэгэнтээ тойроод байрандаа буцаж ирэв.

Сталин ийнхүү улайм цайм дургүйцлээ илэрхийлчихээд байхад Ворошилов өөрийнхөөрөө л хадуураад байна:

-Би ардын комиссарын хувьд эдгээр увайгүй урвагчдыг анзаараагүй төдийгүй, тэдний заримыг илчилж эхлэхээд байхад хүртэл, тэд ямар ч өөгүй ажиллаад байх шиг санагддаг байсан болохоор ийм шившигтэй ялт хэрэг өдүүлнэ гэдэгт итгэж ядаж байснаа ний нуугүй хэлэх ёстой. Энэ тухайд би асар их буруутай. Гэхдээ, нөхөд минь, та нарын зүгээс нэг ч удаа сэрэмж, дохио гарч байгаагүйг би бас хэлэх ёстой...

Олон хүний нүд нь халиран, толгой нь гудайв.

Ворошиловын дуу чангарлаа:

-Бид армийн бүх нүх сүвийг шалгаж цэвэрлэх ёстой! Жинхэнэ хайр найргүй цэвэрлэгээ хэрэгтэй. Хэдийгээр бид тооны хувьд ихээхэн хохирол хүлээх ч гэсэн... Ворошилов бодолхийлснээ Буденный руу харав (цаадах нь уруулаа хөдөлгөсөн боловч юу ч дуугарсангүй). Тэгээд ялагдашгүй Улаан Армийн дийлдэшгүй хүч чадлын тухай улигт үгээр илтгэлээ дуусгав.

Хурал орой болтол сунжирч, маргааш нь, зургадугаар сарын 2-нд ажиллагаагаа үргэлжлүүлэв.

Эхлээд Сталин үг хэлэв. Ворошиловын эмх цэгцгүй илтгэлийг эс тооцвол өчигдөр бүхэлдээ ашигтай өдөр болсон. Цэргийн зөвлөлийн гишүүд, хуралд уригдсан хүмүүс яллагдагсадын мэдүүлгийг сонсоод мэл гайхаж, цэл хөхөрсөн. Одоо мань хүн энд цугласан хүмүүсийн бодол, үйлдлийг зөв зүгт чиглүүлэх ёстой.

Сталин сурсан зангаараа товчхон базаж, нэгдүгээр гол дүгнэлтээ хэллээ:

-Манай оронд германы фашистуудын өөгшүүлэн санхүүжүүлсэн цэрэг-улс төрийн хуйвалдаан, Зөвлөлт засгийн эсрэг хуйвалдаан байжээ. Энэ бол яллагдагсадын өөрсдийнх нь мэдүүлгээр төдийгүй, бидэнд байгаа тэдний уравсан, тагнуул хийснийг илчилсэн жинхэнэ баримт бичгүүдээр нотлогдсон гарцаагүй бодит зүйл. Тэдгээр баримт бичгийг улс төрийн болон тагнуулын ажлын шинжтэй, нийтэд ойлгомжтой учир шалтгааны улмаас би энд нэрлэхгүй.

Сталин хэсэг зуур чимээгүй болов. Цугларагсад энэ санааг нэгдүгээр арцашгүй дүгнэлт хэмээн ухааж ойлгож аваг гэж буй нь тэр.

Тэгээд үргэлжлүүлэв.

-Энэ хуйвалдааны удирдагчид хэн хэн байв? Иргэний шугамаар: Троцкий, Рыков, Бухарин, Рузутак, Карахан, Енукизе, Ягода, цэргийн шугамаар: Тухачевский, Якир, Уборевич, Корк, Гамарник нар. Эд бол цэрэг-улс төрийн хуйвалдааны цөм. Энэ цөм Германы рейхсвертэй тогтмол харилцаж, бүх ажил хэргээ германы фашистуудын захиалгаар, тэдний дур сонирхолд таацуулан явуулж байжээ...

Сталин урт ширээг түрүүчийнх шигээ нэгэнтээ тойров. Ийнхүү тойрохдоо хананы дагуу сууж буй хүмүүсийн царайг сонжин харжээ. Өөртэй нь нэг ширээн дээр сууж буй хүмүүсийн царайг Тэрээр харсан, тойрч ирээд дахин бас харна.

Тэрээр байрандаа эргэж ирэв.

-Хуйвалдааны нэр гарсан бүх удирдагч германы юм уу, зарим нь японы тагнуул байв уу? Үгүй, зарим нь биш. Рыков, Бухарин, Гамарник гурвын хувьд бидэнд одоогоор тийм нотолгоо алга. Харин бусдынх нь тухайд бол тагнуул хийсэн тухай няцаагдашгүй баталгаа байна. Тухачевскийг аваад үзье л дээ. Тэр этгээд манай оператив төлөвлөгөөг, оператив төлөвлөгөө чинь манай хамгийн нандин дархан зүйл шүү дээ, германы рейхсверт дамжуулсан байна. Германы рейхсверийн төлөөлөгчтэй удаа дараа уулзсан. Тагнуул уу? гээд Тэрээр бүгдийг тугалган харцаар тойруулан харав. -Тагнуул!.. Якир Германы штабыг мэдээгээр тогтмол хангаж байсан... Уборевич найз нөхөдтэйгөө төдийгүй, өөрөө биечлэн мэдээлж байсан, Карахан-германы тагнуул, Эйдеман-германы тагнуул. Корк Германд манай цэргийн атташе байх үеэсээ эхлэн Германы штабт мэдээ өгч байж. Гэтэл энэ новшнуудын хямдхан худалдагдсан байгааг! Рузутак, Карахан, Енукизе энэ тэрийг хэн элсүүлэв? Германы рейхсверт алба хаадаг германы тагнуулч дани хүүхэн-Жозефина Енсен. Тухачевскийг элсүүлэхэд бас тэр хүүхэн тусласан. Улс төр, ёс суртахууны доголдол ийм л юманд хүргэдэг байна!

Тэрээр тугалган харцаар бүгдийг дахин ширвэв. Өөртөө эрэмшсэн цэргийн хүнд сурталтнууд одоо айн чичирцгээж байна, бүгдээрээ нэрээ баастах нь энэ.

-Хуйвалдаанд зөвхөн энд нэр дурдсан хориод хүн оролцсон мэт бодож болохгүй. Тэгж бодвол том алдаа болно. Хуйвалдаан армид үр үндсээ гүн гүнзгий суулгасан байна, бид мэлэрч байгаад үүнийг анзаарсангүй. Цэргийн шугамаар дөрвөн зуун хүн нэгэнт баригдаад байна.

Тэрээр түр чимээгүй болов.

-Энэ бол зөвхөн эхлэл гэж бодож байна... Энэ бол цэрэг-улс төрийн өргөн цартай хуйвалдаан. Энэ бол Германы рейхсверийн гардаж хийсэн бүтээл. Эдгээр хүмүүс рейхсверийн гарт орсон тоглоомнууд. Рейхсвер манайд хуйвалдаан гаргахыг зорьсон байна, тэгтэл энэ н о ё д у у д хуйвалдааныг гардан хийжээ. Рейхсвер энэ ноёдоос цэргийн нууц тогтмол авч байхыг зорьсон байна, тэгээд энэ ноёд нь цэргийн нууцыг тэдэнд мэдээлж байсан байна. Рейхсвер манай засгийн газрыг ниргэж, авч хаяхыг хүсч байна, тэд энэ ажилдаа орсон байна, гэхдээ энэ зорилго нь бүтсэнгүй. Дайн болсон тохиолдолд рейхсверийн хувьд бүх юм бэлэн байхаар бодсон байна, арми батлан хамгаалахад бэлэн биш, харин хорлон сүйтгэх ажилд оролцоход бэлэн байх юм гэнэ, рейхсвер үүнийг хүсч, үүнийг бэлтгэж байсан байна.

Тэрээр сандлаа дахин холдуулж, дахиад ширээний хоёр үзүүрийн хооронд ердийнхөөсөө арай түргэн алхаж хэдэнтээ холхив. Грузин аялага нь ч илүү тод сонсдож байна.

-Энэ бол эрх бүхий арван тагнуул, гурван өөгшүүлэгчээс бүрдсэн удирдах цөмтэй тагнуулын алба. ЗХУ-д буй цэрэг-улс төрийн хуйвалдааны удирдах цөм нь тэр. Энэ бол германы рейхсверийн тагнуулууд. Үндсэн зүйл бол энэ. Энэ хуйвалдаан дотоодын хөрстэй гэхээс урьдаар гадаад нөхцөлтэй илүү холбоотой, манай орны дотоод бодлого бус, германы рейхсверийн бодлогоос үүдэлтэй байна. ЗСБНХУ-ыг хоёрдахь Испани болгох гэсэн санаархал.

Тэрээр сандалдаа сууснаа зангидсан гараараа ширээ рүү цохив:

-Алмайрч байж алдсан байна, цэргийнхнээс бид өөрснөө илчилсэн хүн цөөхөн. Манай тагнуулын алба цэргийн шугамаар муу, сул ажиллаж байна, гаднын тагнуул нэвтэрсэн байна, тэр ч бүү хэл чекист тагнуулын албаны дотор хүртэл Герман, Япон, Польш энэ тэрийн төлөө бүхэл бүтэн бүлэг ажиллаж байсан байна... Газар дээрээсээ яагаад мэдээ дохио алга байна вэ?

Тэрээр нүдээ сүүмийлгэн Ворошилов, Буденный хоёр руу харав:

-Яагаад хэн ч мэдээлсэнгүй вэ, яагаад хэн ч сонор сэрэмж гаргасангүй вэ? гэж би асууж байна. Мэдээллийн таван хувь нь үнэн байлаа гэхэд л юм шүү дээ.

Цэргийн зөвлөл зургадугаар сарын 3, 4-нд үргэлжлэн хуралдав. Дөчин хоёр хүн үг хэлжээ. Хуйвалдагчдыг бүгд жигшин буруушааж, өөрсдийгөө санаа амирангүй, сонор сэрэмжгүй байсан хэмээн гэмшицгээжээ. Сталин тэднийг анхааралтай сонсон, цэргийн тусгай шүүхийн бүрэлдэхүүнд хэн хэнийг оруулахаа товлож суув. Өмнөх цаасан дээрээ хамгийн хурц ширүүн ярьсан маршал, арми командлагчдын нэрийг бичиж, заримыг нь буцаан дарж, дахин бичиж авч байв.

Эцсийн бүлэгт цэргийн шүүхийн бүрэлдэхүүнд дараах хүмүүсийг оруулав: Буденный, Блюхер, Шапошников нарын маршалууд, Алкснис, Белов, Дыбенко, Каширин нарын арми командлагчид.

Сталин цэргийн зөвлөлийн хурал дээр ядарсан тул маргааш өглөөний цайн дээр Михаил Иванович Калининыг ирүүлэхийг тушаагаад ойрын зуслан руугаа явжээ.

Михаил Иванович эвлэгхэн өвгөн, Сталин яаж ч дооглож цаашлуулж байсан нэг л янзаараа. Гэхдээ Сталин өвгөнийг юу гэж гомдоохыг бодохов, цагаан цайлган сэтгэлээр л тоглоом хийнэ... Калинин бильярданд муу хэрнээ тоглох дуртай, Сталин үүнийг нь их үнэлнэ, өөрөө дандаа хожно. Сталин бусад хүнийг ч хожих нь бий, гэхдээ түүнийг хожихоосоо айгаад зориуд алдах буюу тавьж өгдөгийг Тэрээр анзаардаг билээ. Харин Калинин бол үнэхээр хийх гэж тоглоно, даанч алдах нь элбэг.

Гурван удаа тоглоод гурвууланд Сталин хожиж, тун урамтай байв. Шарик орж байгаа гэдэг ч жигтэйхэн. Тэрээр Михаил Ивановичийн мөр рүү нөхөрсөгөөр алганд, “Гутрах хэрэггүй ээ, Калиныч, би өнөөдөр хожлоо, маргааш чи хожно, бильярд чинь ийм л тоглоом” гэж хэлэв. Калинин хэзээ ч хожихгүйг уул нь мэдэж байгаа л даа.

Үүний дараа Сталин Кремль рүүгээ явав. түүнийг Молотов, Каганович, Езов гурав хүлээж байгаа билээ. Баригдсан хүмүүсийн жагсаалтыг хянан үзээд, шүүхэд өгөх ёстой найман хүнийг сонгов: Тухачевский, Якир, Уборевич, Корк, Эйдеман, Примаков, Путна, Фельдман. Тэдний хэргийг нэг бүлэг хэрэг болгон нэгтгэжээ.

Зургадугаар сарын 7-нд Сталин, Молотов, Каганович, Ворошилов дөрөв Езов, Вышинский хоёрыг хүлээн авч, ялын төлөвлөгөөний эцсийн хувилбарт эх орноосоо уравсан, тагнуул

хийсэн, алан хядах ажиллагаа явуулсан гэх зүйлийг оруулан батлаж өгчээ.

Зургадугаар сарын 8-нд энэ ялыг бүгдэд нь тулгажээ.

Зургадугаар сарын 9-нд Вышинский, цэргийн ерөнхий прокурорын туслах Субоцкий нар баригдсан хүмүүсийг товч байцааж, тэдний мэдүүлгийн протоколд гарын үсэг зурж баталгаажуулжээ. ДЯАК-ын хэрэг мөрдсөн байцаагчид мөн тэнд байлцжээ.

Сталин энэ өдөр Вышинскийг хоёр удаа хүлээн авсан бөгөөд сүүлчийн уулзалт 22 цаг 45 минутад болсны дараа Вышинский ялын төлөвлөгөөнд гарын үсэг зуржээ.

Вышинскийн дараа Сталин, Молотов, Ежов гурав 23 цаг 30 минутад “Правда” сонины ерөнхий редактор Мехлистэй уулзжээ.

Зургадугаар сарын 10-нд Вышинскийн илтгэлийг хэлэлцсэн онцгой бүгд хуралдаанаар Сталины товолсончлон Ульрих даргатай тусгай шүүхийн бүрэлдэхүүнийг батлажээ.

Зургадугаар сарын 11-нд Сталин Ульрихыг хүлээн авчээ. Молотов, Каганович, Ежов гурав хамт байлцав.

Мөн өдрийн “Правда” сонинд одоо болох гэж буй шүүх ажиллагааны тухай мэдээ нийтлэгдсэн байна.

Сталин мөн энэ өдөр холбооны улс, хязгаар, муж руу даалгавар чиглэл илгээв:

“Тухачевский, Якир, Уборевич болон тагнуул, хорлон сүйтгэгчдийг шүүж байгаатай холбогдуулан ТХ та бүхэнд ажилчдын, бололцоотой газарт мөн тариачдын хурал цуглаан, түүнчлэн улаан армийн ангиуд дээр хурал цуглаан зохион байгуулж, залхаан цээрлүүлэх дээд ял оноохыг шаардсан тогтоол гаргуулахыг санал болгож байна. Шүүх өнөө шөнө дуусах ёстой. Ялын тухай маргааш, өөрөөр хэлбэл, зургадугаар сарын 12-нд нийтлэнэ. 37.6.11. ТХ-ны нарийн бичгийн дарга Сталин”.

Сталиныг ойрын зуслангийнхаа албан өрөөнд унтаж байхад цэргийнхнийг үүрээр буудан алжээ.

Тэрээр арван цагт сэргэж, буйдангаасаа босоод, сэхээвч рүү очиж хөшгөө яраад, гадна талд нь өлгөөтэй буй термометр рүү харвал хорин хэм дулаан байгааг зааж байв.

Сталин кителиэ нөмрөн гадагш гарч, цардмал замаар жаахан явснаа зогтусан ханиалгав. Аливаа тамхичны адил Тэрээр өглөөгүүр баахан ханиалгаж, мэнгэрээ хөнгөлдөг билээ. Энэ удаа агаарт хийсэн буй улиасны хөвөнгөөс болж ханиалгасан ч байж магадгүй.

Дараа нь нүүр гараа угааж сахлаа хусав. Эргэж ирэхэд нь буйдан дээрээс хөнжил дэвсгэрийг хураачихсан, ширээн дээр шинэ сонин тавьчихсан байв.

Валечка өглөөний унд авчирч өгөөд,

-Сайхан унтав уу, Иосиф Виссарионович? хэмээн инээмсэглэв.

-Баярлалаа. Сайхан унтлаа.

-За, яамай даа. Сайхан зооглоорой.

Валечка Сталин руу шууд нар тусахааргүй болгож цонхны хөшгийг татаад, өнөөдөр бороо орохгүй гэж мэдэгдэв.

-Орохгүй гэж яаж мэдээв?

-Шүүдэр их унасан байна. Би саяхан цэцэг авчрах гэж гарсан юм, хөлөө шагайгаа хүртэл ногчихсон.

Саяхан гарсан гэнэ, үгүй ер дөө...

Сталин цайгаа жижигхэн жижигхэн оочлох зуур сонингоо гүйлгэж харав. Тухачевский болон бусад шаарнуудыг буудан алсан тухай мэдээ, яг тэнд нь ийнхүү алсныг ажилчид, хамтралчид, хөдөлмөрийн хамт олон, цэргийн ангиуд, эрдэмтэд, зохиолчид, жүжигчид, зураачид сайшаан дэмжсэн тухай мэдээнүүд нийтлэжээ. Урван тэрслэгчдийг улс тэр аяараа хилэгнэн буруушааж байна. Кировыг алсны маргааш, Зиновьев-Каменевыг шүүсэн анхны шүүх ажиллагааны үеэр, бас хоёрдахийн үеэр, Пятаков-Радекийг шүүх ажиллагааны үеэр, түүнээс бүр өмнө, Аж үйлдвэрийн намыг, меншевикүүдийг шүүх үеэр сонин хэвлэл яг ийм мэдээ материалаар дүүрэн байж билээ... Ард түмэн түүнийг байнга дэмжиж ирсэн. Гэхдээ энэ удаагийнх бол онцгой дэмжлэг. Хуучин бол шүүх хурлууд ил болдог, тэдний мэдүүлгийг нийтлэдэг, тэднийг кино мэдээгээр харуулдаг, ард түмэн бүх юмыг уншдаг, хардаг байсан. Одоо бол иргэний дайны баатрууд, яруу алдарт цэргийн жанжнуудыг хаалттай шүүж байна, ард түмэн тэдний хэргээ хүлээсэн тухай нэг ч үг сонсоогүй. Ард түмэн бахархаж байсан, хайрлаж байсан армийн сор болсон жанжнуудыг шүүж байна.

Тэглээ ч гэсэн ард түмэн тэдэнд биш, ӨӨРТ нь итгэж, тэдний араас биш, ӨӨРИЙНХ нь араас дагаж, хамгийн туршлагатай бөгөөд гол дайсан болох цэргийн бүлэглэлийн толгойг авахад өчүүхэн ч эргэлзэж тээнэгэлзэлгүй туслалаа.

Улс орны дотоодод сүүлчийн аюул бүхий сөргөлдөгчийг бут ниргэлээ. Энэ улсад түүний ганцаарчилсан хязгааргүй эрх мэдэлд өчүүхэн боловч аюул занал үгүй боллоо. Одоо Европын төлөө тэмцэл эхлэнэ. Дэлхийд ноёрхол тогтоох тэмцэл эхлэж байна.

Нэгдүгээр хувилбар. Франц, Англи хоёр Германыг ЗСБНХУ руу турхирна. Тэр бүтэхгүй. Гитлер ард нь шүдээ хүртэл зэвсэглэсэн Франц, Англи хоёр байхад ЗСБНХУ руу хэзээ ч довлохгүй.

Хоёрдугаар хувилбар. Нэг талаас Герман, Итали, Япон, нөгөө талаас Франц, Англи, магадгүй АНУ оролцсон дайн. Аль ч тал нь түүнээс тусламж горилно. Ямар болзол байхаас бүх зүйл шалтгаална. Франц, Англи хоёр түүнд юу санал болгож чадах вэ? Юу ч чадахгүй. Харин Гитлер бол өөртөө Өрнөд Европыг үлдээгээд түүнд славяны улсууд, Балкан хоёрыг өгч чадна.

ЗСБНХУ Азид Хятад, Энэтхэг хоёрыг авна, Япон Зүүн Өмнөд Азийг авна, гэхдээ тэнд Америктай тэмцэлдээд зоогдчихно. мань хүн ойрын жилд дэлхийг иймэрхүү байдлаар хуваахаар төсөөлж байна. Цаг нь болохоор тодроод ирнэ.

Одоохондоо хамгийн сайн хувилбар бол төвийг сахих явдал. Тэд өөр хоорондоо олон жилийн дайнд татагдан орж, хүч тамираа шавхаж байг, тэр хооронд мань хүн хүчээ хуримтлуулж, армийн дайтах хүч чадлыг сэргээж, ЗСБНХУ-ыг хүчирхэгжүүлэн бэхжүүлээд, тамирдаж сульдсан Европт өөрийнхөө нөхцөлийг тулгана. Тэгвээс мань хүн Европын эзэн болно. Тэгвээс мань хүн социалист Европын Нэгдсэн Улсыг капиталист Америкийн Нэгдсэн Улсад сэргүүлэн байгуулна.

Аливаа төлөвлөгөө, төсөлд бодит түүх, үйл явдлын бодит явц засвар, залруулга оруулдаг нь гарцаагүй зүйл. Гэхдээ дэлхийн хувьсгал гэдэг бол домог. Капитализм хүчтэй, зохион байгуулалттай байна, хөрөнгөтнүүд нягтарч бэхжсэн улс бий болгож чадсан. Зөвхөн дайны үр дүнд л улс төрийн байгууллыг үндсээр нь өөрчилж болно. ЗСБНХУ шинэ дайнд ялваас дэлхийн төрийн байгууллыг социалист маягаар, өөрөөр хэлбэл, түүний ЗСБНХУ-д бий болгосон төрийн маягаар өөрчлөнө. түүний буй болгосон төрийн байгууллын тухай үзэл санаа нь хүн төрөлхтний түүхэнд хамгийн хүчтэй, хамгийн үүрдийнх байх болно. Шашны үзэл санаа мянга, мянган жилээр оршин тогтнож байна, гэхдээ энэ бол төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга төдий зүйл.

Хаалга тогшив. Власикийн тогшилт гэдгийг Сталин шууд танив.

-Ор! гэж Сталин уцаар дуугарав.

Власик орж ирээд, хаалганы тэнд зогтусав.

-Чи яах гэв?

-Нөхөр Сталин, эмний тухай сануулах гэсэн юм. Та арван хоёрт гэж тушаасан...

-Мэдэж байна, яв!

Власик гарлаа.

Сталин шүүгээнээс шилтэй эмээ авч, устай хундага руу хорь дусааж уучихаад ярвайлаа. Муухай эм, үгүй, ер нь эмний хэрэг гэж юу байх вэ дээ, сэжгээр өвдөж, сүжгээр эдгэнэ гэдэг биз дээ.

За, юун тухай бодож байлаа?.. Шашны үзэл санааны тухай.

Төр шашнаас төдийгүй үндэстнээс ч хүчтэй. ЗСБНХУ-ын нутаг дэвсгэрт зуу гаруй үндэстэн аж төрж байна, гэхдээ тэдний үндэстний ашиг сонирхол бол нийт улсын ашиг сонирхлын зөвхөн нэг хэсэг. Төр улсын тухай үзэл санаа шинэ зүйл биш, мань хүн ч бодож олсон юм биш, харин төрийг төгс шүтээн болгох санаа бол түүнийх, дэлхийн төр бас түүний бүтээл болно. Тэрээр одоо тавин наймтай, цаашаа их цаг бий. Тэрээр үхэл гэдгийг эс төсөөлнө, тэр

тухай бодох ч үгүй, бодохыг хүсэх ч үгүй, тийм ярианд ч дургүй. түүнийг мах цусанд төрсөн жирийн нэг хүн шиг үхүүлэх гэж түүх өөрийг нь ийм өндөрлөгт гаргасан бус. түүний түүхэн үүрэг одоо л эхлэж байна. Түүхэн үүргээ, үзэл санаагаа бүх дэлхийд түгээсэн хүн л жинхэнэ аугаа их хүн болдог. Түүхэнд дэлхийн эзэнт гүрэн байсан уу? Байсан. Задран бутарсан уу? Задран бутарсан. Гэхдээ тэдгээр эзэнт гүрнүүд бол эдийн засаг, нийгэм, улс төрийн элдэв янзын хэвшлийн цуглуулга байсны гадна дайсагнасан хүрээллийн дунд оршиж байсан. Энэ шалтгааны улмаас задран бутарсан.

Гитлер бас дэлхийн эзэнт гүрэн байгуулахыг санаархаж байна. Гэхдээ Герман хүн л ноён байдаг, бусад нь боол байдаг Германы эзэнт гүрнийг. Тийм эзэнт гүрэн удаан тогтохгүй, дотор нь буй тэгш бус байдал л дэлбэлчихнэ.

түүний байгуулах дэлхийн эзэнт гүрэн нь төрийн н э г д м э л үзэл санаа, нэгдмэл социалист хэвшил, нэгэн хэвийн удирдлага, хатуу төвлөрөл, үнэнхүү нэгдмэл сэтгэлгээгээр зангилагдсан байх болно. Хаа нэгдмэл сэтгэл байна, тэнд хүн ард дуулгавартай байна.

мань хүнд ийм л зорилт тулж ирээд байна. Дахиад нэг, хоёр жил болоход улс орны дотоод нэгдэн нягтрах үйл явц дуусна. Одоо бүх юм амар хэрэгжинэ. Армийг улс төрийн тоглоомноос үүрд хаслаа. ДЯАК түүний гарт байгаа, энэ байгууллагын тусламжтайгаар мань хүн нам, улсын дотор боловсон хүчний хувьсгалыг эцэст нь хүргэнэ.

Цэргийн хуйвалдагчдыг устгасны анхны үр дүн ийм байна. Ингэснээр түүний амьдралд, түүний хувь заяанд шинэ үе нээгдэж байна.

Тухачевскийг цаазалснаас хойш ес хоногийн дараа цэргийн хуйвалдаанд оролцсон хэмээн 980 дээд болон ахлах тушаалын офицерыг баривчилжээ. Тэдгээрт бие махбодины эрүү шүүлт сайн хэрэглэж, шинэ шинэ нэр хэлүүлж авахыг Сталин тушаажээ.

Нөхөр Сталины тушаалыг биелүүлэн, шинээр баригдсан цэргийнхний урт урт нэрсийн жагсаалтыг орой болгон Кремльд авчрах болж, мань хүн тэр жагсаалт дээр “Буудан алах саналтай. И.Ст.” гэж хөх будгийн харандаагаар цохно. Цорын ганцхан удаа буудан алах гэдгийнхээ оронд шоронд хийх гэж бичжээ.

Нөхөр Сталин завгүй байж таарвал нэрсийн жагсаалтыг түүний журмын нөхөд Молотов, Каганович, Ворошилов, Щаденко нарын хэн нэгэнд, эсвэл Мехлист гардуулна. Тэд нар нөхөр Сталин шиг “Буудан алах саналтай” гэж цохно. Гэхдээ нөхөр Сталинаас ялгаатай нь хэний ч буудан алах ялыг хорих ялаар солиогүй. Айцгааж байхгүй юу.

Тухачевскийг шүүсэн долоон жанжнаас Блюхер, Белов, Дыбенко, Каширин, Алкснис тав төдөлгүй өөрсдөө цаазлуулжээ. Зөвхөн Шапошников, Буденный хоёр мэнд үлджээ.

Цэргийн зөвлөлийн зуун найман гишүүнээс зөвхөн арван хүн амьд үлдсэний дотор Ворошилов, Шапошников, Буденный гурав оржээ.

Цэргийн зөвлөлийн хурал дээр үг хэлсэн дөчин хоёр хүний гучин дөрвийг буудан алсан бөгөөд мэнд үлдсэн наймын дотор Ворошилов, Шапошников, Буденный гурав байлаа.

Бүтэн хагас жилийн дараа, 1938 оны арван нэгдүгээр сарын 29-нд Батлан хамгаалахын ардын комиссар Ворошилов, “1937, 38 оны турш бид өөрсдийнхөө эгнээг хайр найргүй цэвэрлэх ёстой байлаа... Хамгийн дээд оройноос эхлээд бүр ёроол хүртэл бүх талыг хамарсан, үндсэн цэвэрлэгээ хийлээ... Бид дөрвөн түм гаруй хүнийг хуу шүүрдэн цэвэрлэлээ...” гэж ам бардам мэдэгджээ.

Энэ хамгийн боловсролтой, туршлагатай, авьяаслаг дөрвөн түм гаруй хүн бол Улаан Армийн дээд болон алхах тушаалын командлалын тэн хагасаас илүү хувь нь юм.

Нөхөр Сталин Зөвлөлт Холбоот Улсыг ирээдүйн дайнд ингэж бэлтгэж байжээ.

Сергей Алексеевичтэй нүүрэлдүүлсний дараа Альтман юун цэргийнхний тухай асуусныг Вадим сая л таамаглаж эхлэв.

Арбатын ойролцоо Большой Ржевскийн хөндлөн гудманд Гамарник, Уборевич, Муклевич, бас өөр хэн ч билээ, цэргийн томчуул амьдардаг билээ. Зөвлөлтийн тэнгисийн цэргийн хүчний командлагч Ромуальд Адамович Муклевичийг Вадим хэд хэд харсан юм. Тэнгисийн цэргийн дүрэмт хувцастай сайхан адмирал гудамжаар явган явж байдаг сан. Гэхдээ явган хүний замаар биш, бүр гудамны голоор, зөрсөн хүмүүс рүү толгой мэхийн, хүүхэд багачуул руу инээмсэглэн алхлана. Яагаад явган, яагаад замын голоор явж байсныг бүү мэд.

Нэг удаа ярианы явцад Сергей Алексеевич Муклевичийг таньдаг болох нь ойлгогдсон билээ. Сергей Алексеевич сард нэг юм уу, хоёр удаа тэр Большой Ржевскийн байранд очиж үйлчлүүлэгчдийн үсийг засна. Тэрээр Муклевичийн тухай “Том дарга” хэмээн тун сүжигтэй өгүүлжээ.

Тэгэхээр энэ “том даргаас” болж л Сергей Алексеевичийг зовоож байх нь, тиймгүй бол Альтман юу гэж цэргийнхний тухай асуухав. Вадимын мэдүүлэг өгснөөс хойш үсчнийг харуулах болж, хэн ирж үйлчлүүлдэг, хэнийд очиж үйлчилдэгийг нь мэдэхийн тулд гэрийнх нь ойролцоо, үсчнийх нь ойролцоо “отоочингуудыг” тавьж байгаад, Муклевич дээр буучихсан байх нь. Бөөн олз. Сергей Алексеевич өөрөө тэдэнд хэрэггүй, харин Муклевич бол хэрэгтэй, бас түүний үйлчилдэг цэргийн томчуулаас өөр хэн нэгэн хэрэгтэй ч юм сан уу? Чухам энэ учраас Сергей Алексеевич ямар ч хал балгүй үг хэлэх төдийгөөс огт гэм буруугүй хүнийг хөнөөлгөж мэднэ гэдгийг ойлгоод, юу ч хэлэхгүй байж л дээ. Гэтэл цаадуул нь хал балгүй зүйл хэлүүлэх гээгүй, Муклевич Сталины эсрэг юм ярьсан, Радекийн тухай онигоог дэмжин инээж байсан гэж шууд хэлүүлэх гэсэн бололтой. Тэгээд Муклевичийн байранд цэргийнхэн цуглаж, Сталиныг шүүмжилж байсан гэх мэтийн балай юм нотлуулах гээд нотлож өгөхгүй болохоор нь шүдийг нь цөм цохьсон байх. Цус нөжтэй нь хутгаад байхад л, хөөрхий Сергей Алексеевич нөгөө нүүрэлдүүлэхэд “үгүйсгэж байна” гээд байсан шигээ өөр юу ч хэлээгүй биз. Ямар ч тэсвэр хатуужил гаргаад юу ч өөрчилж чадахгүй гэдгээ ойлгосонгүй. мань хүн зохиомол мэдүүлэг өгсөн ч, эс өгсөн ч Муклевичийг цаазалдгаараа цаазлана, харин өөрийг нь зүгээр л мугуйдалж зөрүүдлэсэн гээд шоронгийн тав болгочихно. Гэхдээ Вадим юу гэж ч бодож, өөрийгөө юу гэж ч зөвгөлөө гэсэн чухамхүү мань хүн Сергей Алексеевичийг энэ нүх рүү түлхсэн, хар амиа бодож тэр сайн хүнийг авсалсан гэдэг яах аргагүй баримт.

Тэрээр далд нэр нь хэзээ ч задрахгүй гэж эхэндээ найдаж байсан бол Альтманы нэг ч үгэнд итгэж болохгүйг одоо ойлгожээ. Альтман өнөөдөр түүнийг хүнтэй нүүрэлдүүлж байгаа юм чинь маргааш шүүх дээр гэрчээр чирээд очихыг хэн байг гэхэв. Афиногеновын “Алслахуйд” ямар зорилгоор албан ёсны шүүмж бичихийг түүнээс шаардав? Өөрөө ч гэсэн ёстой мангар толгой, өөрийнхөө нэрээр бичиж гаргана гэж юунд зөвшөөрнө бол доо? Афиногеновоор үзүүлэх сургууль хийж шүүнэ, тэгээд Вадимын нэрээр гарсан нөгөө шүүмжийг эд мөрийн баримт болгож ашиглана, чингэхүйд мань хүний хэн болох нь нийтэд тодорхой болно. Тэгвэл хамаг төлөвлөгөө, хамаг мөрөөдөл нь хийсэн арилна. Ивээгчид нь хараа буруулж таарна, нууц ажилтан-Караморыг дэмжих сонирхолтой хэн байх вэ дээ, ингээд дорвитой юм юу ч

бичихгүй болно гэсэн үг.

“Карамора!” Сергей Алексеевичтэй нүүрэлдүүлсэн өдөр мань хүн хаант засгийн харгис цагдаагийн туршуул, шивэгчний тухай Горькийн тэр өгүүллэгийг яг очиж очиж санаж байгаа юм даа. Горькийн нас барсны нэг жилийн ойг тэмдэглэх үеийн түүний хөрөгтэй сар гаруйн өмнөх нэг сонин жорлонд нүдэнд өртөнгүүт “Карамора” гэсэн бодол толгойд нь зурсхийгээд явчихжээ! Гэтэл Горький ямар билээ дээ? Беломорканалийн барилга байгууламжийг биширч, чекистүүдийг тэнгэрт тултал дөвийлгөж, Сталиныг шагшиж магтаад зогсоогүй, түүний гарт “Хэрвээ дайсан бууж өгөхгүй бол түүнийг устгадаг юм” гэдэг аймшигт лоозон бариулж өгсөн. Горькийд “Карамор”-ыг бичихэд юу байх вэ дээ, түүн шиг өндөрлөгт гарсан, бат бэх байр суурьтай хүн хорин зургаахан насандаа нэг муу онигооноос болоод толгойгоо з ү в з ү г э э р өгчих зүрх дутаж, ийм нөхцөл байдалд о р ч и х с о н хүнийг муучилж бичихэд зовлон байхгүй. Эльсбейн гэж нэг муу өдөөн хатгагч мөрөөрөө сууж байгаа хүний дэргэд онигоо ярьчихаад, өөрөө эхлэж очоод ховлочихсон байгаа юм даа.

“Вадим Андреевич, Вадим Андреевич...” Энэ үг чихэнд хангинан, Сергей Алексеевичийн зодуулж нүдүүлж, зовж тарчилсан царай нүдний өмнө тодроод болж өгөх биш. Сергей Алексеевич үнэнээ хэлчих нь яав аа, түүнийг шууд бариагүй байлгүй, тэдний ярьдгаар эхлээд ярилцлага хийх гэж дуудсан байлгүй. Үнэнээ хэлсэнгүй, хэнийг ч илчилсэнгүй! Эсвэл энэ өвгөчүүл үхэхээс айдаггүй юм болов уу? Нэмэрт нь Сергей Алексеевич сүсэгтэй хүн байх, тэгээд “худлаа бүү гэрчил” хэмээх бурхны сургаалийг яаж зөрчихөв. Гэхдээ тэр онигоог Вадимаас сонссон гээд нотлочиход үнэнийг л хэлсэн хэрэг болно шүү дээ!

Тэр нь ч тийм. Гэтэл ДЯАК-ынхан хэн нэгэнд ярьсан онигоог зөвлөлтийн эсрэг суртал ухуулга, гэмт хэрэг гэж ангилан үздэг, тэгэхээр Вадимыг гэмт хэрэг хийсэн гэж Сергей Алексеевич гэрчилж чадах ч үгүй, хүсэх ч үгүй. Уул нь анх байцааж эхлэхэд л Вадим түүнийг ялд унагасныг таамаглах ёстой байсан л даа.

Ямар муухай юм бэ?.. Хэдийдээ ийм хүний адаг болчихсон билээ? мань хүн энэ бүхэнд чинь сэтгэлээсээ итгэж байсан юм чинь. Комсомолд чин сэтгэлээсээ элссэн. Тэгэхэд зарим хүн түүнийг дэвших арга зам хайж, дээд сургуульд ороход амар гэж л элссэн хэмээн гоочилсон тал бий. Тэр ёстой гүтгэлэг! Тэрээр шинэ хүмүүс шинэ ертөнцийг цогцлон байгуулж буйг нүдээрээ хараад, тэр хүчтэй, шийдвэртэй, өөрсдийнхөө зөв гэдэгт төгс итгэсэн хүмүүс рүү татагдаж, тэдэнтэй х а м т, м ө р з э р э г ц э ж явахыг хүссэн билээ. Тэгж яривал тэдний үзэл санаанд итгэсэн нь зөвхөн мань хүн биш. Эцгийнх нь найз нар болох бурхан шиг толгойтой, сод авьяастай хүмүүс гучаад оны бүтээн босголтын хэмжээ далайцыг бишрэн бахдаагүй гэж үү, Орост өөр зам байхгүй гэж нотлож байгаагүй гэж үү? Гэхдээ одоо тэдний тухай ярих явдалгүй. Тэд нар биш, мань Вадим л Сергей Алексеевичтэй холбогдсон тэр хэрэгт орооцолдчихоод байгаа шүү дээ. Ичиж үхмээр юм. Үгүй, ядахад, халуун байгааг ээ. Хүйтэн шүршүүрт ордог юм бил үү? Гэтэл угаалгын өрөө хүрэх ч тамир алга...

Ээ, тэнгэр минь, элэнц эцэг маань яах гэж Польшоос Орос руу нүүж ирэв ээ?! Үр ач нарынхаа амьдралыг ингэж баллах гэж. Вадим Варшавт төрсөн байлаа гэхэд, Оксфорд юм уу, Сорбонныг төгссөн байлаа гэхэд мань хүн шиг ажилсаг, үзэгний жолоо сайхан барьдаг эр өдийд шившгийн өгүүлэл энэ тэрхэн бичих бус, аль хэдийн нэртэй төртэй болчихгүй юу. Тэнд хүмүүсийн багалзуурыг шахах, амыг барих тухай ойлголт байхгүй, хүний намтрыг

бузарлахгүй. Төр улс ямар дайсантай тэмцэж байна? Үсчин Сергей Алексеевичтэй юү? Ингэхэд, Юрка Шарок л онигооны тухай санааг хэлж өгсөн шүү дээ. Тэгэхэд өөрт нь ямар ч тус хүргээгүй, харин ч болвоос Альтманд Саша Панкратов, Вика хоёрын тухай хошуу өргөсөн байна лээ. Харин онигооны тухайд бол Ершилов, үгүй бол Эльсбейн, аягүй бол хоюулаа ч хов хүргэсэн байхаас зайлахгүй.

За яахав, шүршүүрт орох минь.

Тэрээр угаалгын өрөөний үүдэнд очтол хэн нэгэн хүн тэдний

давхарт цахилгаан шатнаас гарч, тэгтэл ч үүдний хонх хангинах нь тэр. Вадим овсхийн цочиж, Феня руу харайлгав.

-Би дотуур өмдтэй байна, чи хаалгаа онгойлгож өг.

Сайн хүн санаагаараа гэгчээр Ершилов юм санж.

-Залуу зайсан хаа байна?

“Ирэхийнхээ өмнө утасдаж бай” гэж зуун удаа хэлсэн, бас өөрийг нь битгий “залуу зайсан” гэж бай гэж бас зуун удаа гуйсан.

-Би энд байна, наашаа ор гэж Вадим хэлэв.

-Чи яасан бэ, хувцаслаагүй байгаа юм уу? Зургаан цагт Зохиолчдын хороон дээр машин хүлээж байна гэсэн шүү.

Жуковскийн нэрэмжит Цэргийн академийн сонсогчидтой өнөөдөр уулзах товтойг Вадим таг мартчихсан юм байж.

-Би нүд ирмэхийн зуур хувцаслачихна, чи суу, манайд зуслан дээрээс түүсэн жимс бий, Феня чамайг дайлна хэмээн Вадим шуурхайлав.

Ершилов ирсэн нь юун сайн юм бэ, сэтгэл дорхноо сэргээд явчихлаа, Вадим уншигчидтай уулзахаас хэзээ ч татгалздаггүйг ч хэлэх үү. Оросын ард түмэн унтах нойр, уух идэхээ хасч байгаад ч хамаагүй амьд зохиолчид, жүжигчдийг харах гэдэг, аягүй бол ойроос нүд хужирлана, танилцана гэдэг улс.

Үүдний танхимд өөрийгөө Хохлов хэмээсэн цэнхэр нүдтэй, за-луухан нисгэгч Вадим руу наалдаж, утга зохиолын тухай ярина гэж зүтгэв. Алексей Толстой, Леонов хоёрыг унших дуртай, инээмээр санагдвал Зоценког уншдаг гэнэ.

-Та юун тухай бичдэг вэ? гэж Тэрээр асуулаа.

-Янз бүрийн юм бичнэ гээд Вадим түүнээс хараа буруулав. Уулзалтад ирж байгаа юм бол зарлал дээрх нэрсийг сонирхох хэрэгтэй биз дээ.

Уулзалт дээр эхлээд Ершилов үг хэлнэ, дараа нь Анна Каравалева, гуравт нь Семен Кирсанов хайр сэтгэлийн тухай шүлгээсээ уншина гэж очиж явахдаа тохирцгоож. Вадим хөтөлбөрийг сунжруулахгүйн тулд зөвхөн нөхдийгөө чих тавин сонсоно хэмээжээ.

Вадим Ершиловын сэхээтэн, ард түмэн хоёрын холбооны тухай бурахыг чихнийхээ хажуугаар өнгөрөөх зуур тэргүүлэгчдийн байрнаас танхимыг эргүүлдэн харж суув. хүн их цуглажээ. Цэнхэр нүдэт Хохлов гуравдахь эгнээний захад нэмж тавьсан сандал дээр өнцөгдөсхийн суусан харагдана. Шүтэх хүнээ мөн олов оо. Толстой, Леонов, Зошенко гурав гурвуулаа Тухачевскийг цаазаар авахыг шаардацгаасан. Тэдэн дээр Пастернакийг нэмэх хэрэгтэй, тийм ээ, Пастернак ч тэссэнгүй. Вадим сонин дээрээс бусад нэрний хажуугаар түүний нэрийг олж хараад баярласандаа болж чичирсэн гэж байгаа. “Хонгорууд минь, ямар гэгч мянган жил хаяанд ирээ вэ?” Ийм л мянган жил ирж дээ! Бүгд гарын үсгээ зурсан: Всеволод Вишневский, Василий Гроссман, Тынянов, Паустовский, Константин Симонов, Антокольский, Федин, Шолохов, Фадеев, Тихонов гээд бүгд... Энэ бүхэн болдог эд байх нь ээ дээ? Тэгвэл мань хүн өөрийгөө зүхэх хэрэг алга. Сергей Алексеевичид муухай явдал тохиолдсон нь мэдээж, ойлгомжтой, гэхдээ энэ хожим хэзээ ч давтагдахгүй, Вадим туршлагагүйдээ л Альтманд дөрлүүлчихэж. түүний хийж буй бусад зүйлийн тухайд гэвэл харин ч илүү хүмүүнлиг биз дээ? Тэрээр хэнийг ч шоронд хийгээгүй, хэнийг ч буудан алахыг шаардаагүй, зөвхөн аль нэг утга зохиолын бүтээлийн талаар өөрийнхөө санаа бодлыг л зүгээр бичиж байгаа. Түүгээр барахгүй түүний бичсэн зүйл зөвхөн Альтманд л хэрэгтэй, харин Алексей Толстой буюу Леоновын нийтэд хэлсэн үг баривчлах, шүүх, цаазлахыг хэдэн арван сая хүний өмнө зөвтгөж байна.

Мэдээж, энэ эрхэм зохиолчид бөөн бөөнөөрөө гарын үсэг зурж байгаа учраас сүргээрээ байна, ханиндаа байна гэж өөрсдийгөө тайвшруулж байгаа. Уг ухаан нь тэр нь тэднийг зөвтгөх юм биз дээ. Үгүй, зөвтгөж байгаа юм биш. Зүгээр л хүн бүр амиа аварч байгаа хэрэг: Эсрэг үг хэлвэл алуулна, санал хэлэхээс татгалзвал алуулна, нийтийн захидалд гарын үсэг зурахгүй гэвэл алуулна.

Хэрвээ тийм бол түүн рүү бас чулуу шидэхийн хэрэггүй! Альтман түүнд, “Вадим Андреевич, та бидний ард нуугдаагүй байсан сан бол аль хэдийн годройтож арилах байсан” гэж тов тодорхой хэлсэн. Ер нь шорон, үхэл хоёр бол эцсийн бүлэгт утга нэг зүйл. Тийм учраас худлаа гоёчилж дүрэмдэхийн хэрэг алга, бүгдээрээ нэрээ баастсан нь илт байна, үүнийгээ л хүлээн зөвшөөрцгөөе.

Тэглээ ч гэсэн тэд нар үр хүүхдийнхээ өмнө өөрсдийгөө цайруулах гэж оролдоно, “Тийм л цаг байсан юм” гэж хэлнэ, “Бүх юманд үйлийн үргүй итгэж төөрөлдөж явжээ” гэж хэлнэ, тэгэхээр цаадуул нь тэднийгээ ойлгоод өршөөж магадгүй. Гэтэл “нууц мэдээлэгчийн” им тамгыг хэзээ ч арилгаж чадахгүй.

Ершилов үгээ дуусгаж, алга ташилтын хариуд мэхийн ёслоод, Вадимын хажууд эргэж ирж суулаа.

-За, ямар вэ?

-Сайн байна, дажгүй.

-Өө, тийм үү, чам руу нэг харсан чинь гомдчихсан ч юм шиг харагдаад, дэмий балай юм ярьж байна гэж бодоо юм болов уу гэж саналаа.

-Чамд л тэгж санагдаж л дээ, чи эр хүн, дажгүй болсон!

Ершилов ёстой шулам, түүнээс юм нууна гэсэн ном байхгүй. Урамгүй царайтай байгааг нь харчихаж. Одоо элдэв юм шалгаагаад салахгүй ээ.

Вадим Ершилов руу налсхийн,

-Толгой өвдөөд болох биш... Би сэмхэн алга болчихъё, чи

аргалаарай. Галт тэрэгний буудал руу эгчийгээ тосох гээд явчихсан гэж хэлээрэй...

Вадим оройн арван цагийн үед гэртээ ирэхэд, эцгийнх нь өрөө ч гэрэлтэй, Фенягийнх ч гэрэлтэй байсан боловч хэн ч өрөөнөөсөө гарч ирсэнгүй, түүнийг хэн ч тоссонгүй. Айл биш, гэр бүлийн бунхан гэлтэй. Тэр гал тогоо руу орж хөргөгчнөөс бөөрөлзгөний ханд гаргаж, том аяганд хийв.

Юугаа хийж, хуйхаа маажих вэ?

Далд орох газар алга. Сонгосон замаараа л тууштай явахаас өөр гарц алга, мань хүн утга зохиолын ажилтан, өөр хэн ч биш! Сонин, сэтгүүл, хэвлэлийн газарт зориулж ямар шүүмж бичиж байсан бэ, яг л тийм шүүмж цаашдаа ч бичиж байх болно.

Сергей Алексеевичийн тухайд бол үнэхээр гунигтай, бэрх, муухай юм болсон, гэхдээ одоо яая гэхэв, тус нэмэр болох аргагүй, засч залруулах ч арга байхгүй! Харин нүүрэлдэх үед Вадим шудрага, эрэлхэг зан гаргаж, бүх бурууг өөртөө хүлээж, санаанаасаа нэг ч үг зохиогоогүй, хэнийг ч гүжирдэж гүтгээгүй. Нүүрэлдүүлсэн уулзалтын протоколыг хэнд ч үзүүлсэн бэлэн, хэн ч түүнийг муу хэлэх үндэс байхгүй. Сергей Алексеевич бүх юмыг үгүйсгэж байсан, гэхдээ уг хэрэг явдал болоогүй учраас биш, өөрийн гэсэн ямар нэг зарчмаасаа болж л үгүйсгэсэн нь хэнд ч тодорхой. түүнээсээ болж хохирсон.

Саша Семен Григорьевичийн хичээлд очсонгүй. Цаг дэмий үрэхийн хэрэг юу сан билээ. Уншлагын танхимд жаахан суух юм уу, кино үзсэн нь дээр, гурван жилийн дотор олон кино үзэж чадалгүй өнгөрөөчихсөн юм чинь. Семен Григорьевич, Глеб хоёрын аль нэг үйлдвэр заводын улаан буланд, чухамдаа газрын мухарт хийдэг хичээл бол хөнгөн олз хөөсөн ажил төдий зүйл, Саша үүнийг юуг нь сонирхох вэ дээ.

Бүх юм сонин биш байна. Амьсгалах ч юм алга, амьдрах ч юм алга. Уяа нь улам чивчрэн богиносож байгааг арьс махаараа мэдэрсээр байна. Уул нь бүх юм ёсоор буй мэт мань хүн өглөө бүр ажилдаа ирж, зам явахаа бичүүлж, шугаманд гарч, барилга руу туйпуу зөөж, төлөвлөгөөгөө давуулан биелүүлж байгаа атал хүндэт самбарт нэр нь нэг ч удаа гарсангүй. Энэ хүндэт самбар түүнд ёстой падгүй л дээ, гэхдээ өөрийнх нь үзүүлэлтүүд гавшгайч гэгдээд байгаа хүмүүсийнхээс дутуугүй байдаг билээ. Айцгааж байгаа хэрэг. Хэрвээ түүнийг бариад явчихвал хүндэт самбарт түүний зургийг хадсан хүмүүс ёстой муугаа үзнэ. Автобаазын дарга, нам, үйлдвэрчний дарга гурав гарцаагүй годройтно. Тэгээд сонинд, “Дайснууд ба тэднийг өмөөрөгчид” гээд биччихнэ. Бүгдийг шоронгийн тав болгоно.

Саша цэргийн хэлтэст очихоо яарахгүй байсан чинь зарлан дуудах хүрээд иржээ.

Цэргийн хэлтсийн албан хаагч нэг ахмад Сашагийн паспортыг баахан эргүүлснээ,

-Шүүхээр шийтгүүлсэн үү? гэж асуув.

-Тэгсэн.

-Зүйл анги?

-Тавин наймын арав.

-Хэзээ баригдсан юм?

-1934 оны нэгдүгээр сард.

-Цэргийн алба хаасан уу?

-Үгүй.

-Яагаад? Гучин дөрвөн онд та хорин гуравтай байсан байна.

-Би Тээврийн дээд сургуульд сурч байсан юм, манай сургууль цэргийн гадуурх дээд зэргийн бэлтгэлтэй байсан.

Саша ахмадад дүнгийн дэвтрийнхээ “цэргийн хэрэг”-“сайн” гэсэн хүснэгтийг үзүүлэв.

-Танд цол олгосон уу?

-Үгүй, би дипломоо хамгаалахаас өмнө баривчлагдсан.

-Суузтаж бай.

Ахмад Сашагийн паспорт, дүнгийн дэвтэр хоёрыг авч, хажуугийн өрөөнд орж ирээд, албан хуудсан дээр Сашагийн нэр овгийг бичив.

-Ингээд эмнэлэгт оч, хаяг нь наана чинь байгаа, эрүүл мэндийн үзлэгээр орчихоод, баасан гаригт наашаа комисс дээр ирэх хэрэгтэй. Таны зарлан дуудах энэ байна, ажлынхаа газар үзүүлээрэй.

Саша эмнэлэг дээр очиж, эмч нарын өрөөгөөр ээлжлэн орж, зүрх, уушиг, даралт, хараа, сонсголоо шалгуулж, өндрөө хэмжүүлж, өдрийн төгсгөл рүү бүх үзүүлэлтээ бөглүүлж авчээ. Ямар нэг өвчин эмгэг алга, эрүүл гэж оношлуулаад тавдахь өдөр комиссоор оров.

Нөгөө ахмад Сашагийн бичиг баримтыг авч, хажуугийн өрөөнд орсноо, дараа нь түүнийг дуудав. Ширээний ард үсээ адилхан арагш нь дарж самнасан, догшин харцтай, албархуу царайтай гурван цэргийн дарга сууцгааж байв. Дарга нь эмнэлгийн дүгнэлтэд хавсаргасан бяцхан хуудсыг нөгөөдүүлдээ гарын үсэг зуруулахаар өгөөд,

-Дайны цагт жагсаалын бус албанд тэнцэнэ гэж хэнэггүй мэдэгдэв.

Саша тийм цэргийн батлах хүлээж авлаа. Нөгөө цэргийн гадуурх дээд зэргийн бэлтгэлээр орсон, эв эрүүл хүн чинь “жагсаалын бус албан тэнцэхээр” болов. Ангийн дайсанд зэвсэг итгэж өгч болохгүй, барилгын батальонд юм уу, гал тогоонд алба хаах нь.

Автотээврийн удирдах газрын боловсон хүчний дарга Кирпичева гэдэг хэнхдэг нь татсан дохигор авгай тэдний баазад хэд хэд иржээ. Сашаг замын хуудсаа бичүүлж байх хооронд түүн рүү муухай хараад байж. Энэ бол муугийн ёр.

Эргэн тойронд ой тойнд багтамгүй юм болж буйг ч хэлэх үү. Муж, районы намын хорооны дарга нар, гүйцэтгэх захиргааны дарга нар, ардын комиссар, тэдгээрийн орлогчид хийсч байна, тэр ч бүү хэл, дотоодыг хамгаалахынхныг хүртэл шоронд хийж байна. Тэдний баазын Опочка руу явж ирсэн хоёр жолоочийг баривчилж, бусдыг нь байцааж эхлэжээ. Тэднийг юу гэж, юун тухай байцааж байгааг өөрснөө ердөө ярихгүй, ам алдахгүй гээд гарын үсгээ зурчихсан хойно аргагүй биз. Автотээврийн удирдах газрын дарга Табунщиковыг баривчилсан гэнэ. Саша түүнийг мэдэхгүй, хэзээ ч хараагүй, гэхдээ баривчлагдахаас нь өмнө хүмүүс түүнд ам сайтай байсныг мэднэ.

Саяхан улс төрийн сонсгол дээр намын дарга Чекин Папанин, Федоров, Ширшов, Кренкель нарын туйлын шинжилгээний ангийнхан Хойт туйлд хүрсэн тухай, энэ нь хүн төрөлхтний түүхэнд Хойт туйлд хүрсэн анхны аялал болсон тухай уншиж сонсгосон юм. Гэтэл цахилгаанчин Володька Артемкин босоод, “Анх Хойт туйлд бүр 1909 онд Пири гэдэг америк хүн нохой хөллөсөн чаргаар хүрсэн” гэж хэлчихээд суучих нь тэр. Чекиний нүд орой дээрээ

гарчихаж: Зөвлөлтийн ард түмний яруу алдарт хөвүүдээс нэг муу америк өрсөнө гэж юу байсан юм бэ! Артемкин дуугүй л байвал болохгүй юу, гэтэл мань хүн дахин босоод, Пиригийн тухай номыг авчирч үзүүлбэ гэдэг байгаа. Чекин уур нь шатаж, хөрөнгөтний элдэв худлаа донгоссон зүйлийг энд уншдаг газар биш, Артемкин манай зөвлөлтийн туйлчдын амжилтыг басамжлах санаатай байна, түүнийг энд, ажилчдын цуглаан дээр хорт ухуулга хий гэсэн хүн байхгүй энэ тэр гэж хашгичив.

Улс төрийн сонсголд бүгд суух ёстой, бултах газар байхгүй учраас Саша ч тэр сонсгол дээр байжээ. Хэдийгээр Артемкиний зөв гэдгийг мэдэж байсан ч дуугарсангүй. Автобааз дээр мань хүн ер нь дуугарахгүй, энэ удаа ч бас дуугарсангүй. Володька Артемкин маргааш нь ажилдаа ирсэнгүй, тэгсэн чинь урьд шөнө түүнийг баривчилсан юм байж. Хамаг юмы нь бусниулж хаячихаад зарим номыг нь аваад явсан гэх. мань хүн номын хорхойтой, номноос өөр элбэг юм түүнд байхгүй. Тэгээд Володя Артемкин балрах нь тэр.

Саша тэр өдөр барилгын бригадын даргатай муудалцжээ:

-Муусайн тэгмэрүүд, ачаа буулгахыг хүлээж хичнээн зогсох юм бэ! Олигтойхон хөдлөөч ээ, явуут л унтаад байх юм! хэмээн мань хүн биеэ барьж чадахгүй баахан хашгичив. Өөртөө шарлахсан шараа гаргаж байгаа царай нь тэр.

Дуугүй өнгөрсөн нь зөв үү, буруу юу? Артемкин тэр хоёрын хэн нь шудрага байв?

Володя Артемкин шудрага, Саша ухаалаг хийжээ. Тэр шулмын Пири хойт туйлд үнэхээр эхлэж очсоныг мань хүн нотлож хэллээ гэхэд Артемкинд тус болох байсан уу? Тэр шөнө нь Володькатай хамт баривчлаад л аваад явах байсан, тэгээд тэр хоёрт автобааз дээр хувьсгалын эсэргүү байгууллага байгуулсан хэрэг тулгачихна. Тэгээд л хоюуланд нь арав, арван жил наачихна. Тэглээ ч гэсэн сэтгэл онгойхгүй нь. Шорон орон үзсэн хүн тэр муу харалган Артемкин яаж зовохыг төсөөлөлгүй яахав. Яах вэ, яахав? Худлаа хэлэх нь нийгмийн ёс суртахуун болчихлоо, үг хэлэх тоолондоо худлаа ярьцгааж байна. Босох, сөрөх хүн нэг ч алга, хүн болгонд айдас шигтгээд зоочихож. Сашад өөрт нь ч гэсэн айдас зоолттой байна, мань хүн одоо ингээд энэ намагт шигдээд эхлэлээ. Тэнгэр минь, тэсэх хүч заяаж хайрлаач, энэ шаварт далд ортлоо зоогдчихгүй байх юм сан.

Саша маргааш өглөө нь автобаазаас гарч Зөвлөлтийн гудамжинд машинаа түр зогсоож, гудамжны цаад талын сонингийн мухлаг руу очив. “Правда” сониныг нээж, Тухачевский, цэргийн бусад жанжныг эх орноосоо урвасан тагнуул, хорлон сүйтгэх явууллага хийсэн хэргээр баривчлан, шүүхэд өгсөн тухай ЗСБНХУ-ын Прокурорын газрын мэдэгдлийг уншаад дуу алдав. Арван хоёрдугаар сарын 1-ний өдрийн хуулиар тогтоосон журмын дагуу шүүх хурал өнөөдөртөө болох аж.

Саша бусад гарчгийг гүйлгэж харав: Metallургчидын тухай тэргүүн байна, академич Тарлегийн “Наполеон” гэдэг номыг өмгөөлсөн өгүүлэл, хөдөлмөрийн фронтын амжилтуудын тухай, баскуудын хөл бөмбөгийн баг ирсэн тухай зэрэг мэдээ байна. Тэгээд буудан алахыг шаардсан хурал цуглааны тухай мэдээнүүд.

Саша мухлаг руу буцаж очив:

-“Известия”, “Комсомольская правда” хоёрыг бас өгнө үү.

-Та өнөөдөр хоосрох вий хэмээн худалдагч авгай инээмсэглэв.

-Гайгүй биз дээ.

Аюумшиг. Зохиолчид, жүжигчид, найруулагчид, академичид, зураачид, ажилчид, хамтралчид Тухачевский болон цэргийн бусад жанжныг цаазаар авахыг шаардацгаажээ. Түрүүчийн шүүх хурлууд нээлттэй болдог, сэтгүүлчид, тэр ч атугай, гадаадынхан байлцдаг учраас шүүгдэгсэд хэргээ хүлээсэн гэдгээр бүхнийг зөвтгөн, ам хаадаг байсан. Гэтэл одоо х а а л т т а й шүүх хурал. Тэгвэл юу мэдсэндээ буудан алахыг шаардаж байна вэ? Алах, цаазлахыг Орост хэзээ нэгэн цагт сайшаадагсан бил үү, алуулсан хүний хүүрийг гишгэчин, ид бах болгон хашгичиж, элдвээр муучилдаг сан бил үү? Толстой цаазаар авахыг эсэргүүцэн, “Дуугүй байж чадахгүй нь” хэмээн бичиж байсан. Бас Пушкин нэгдүгээр Николай хаанд, босогчдын хамт 14-нд Сенатын талбай дээр байж болох байснаа хэлэхээс айгаагүй, “Сибирийн уурхайн гүнд” хэмээх шүлгээ илгээхээс эмээгээгүй.

Хэрэвзаяа улс орон даяар цуглаан болж байгаа юм бол өнөөдөр гэхэд л Калининд үсэрхийлээд ирнэ, тэдний баазад ч бас ирнэ гэсэн үг. Одоо яадаг хэрэг вэ? Бусдын адил саналаа өгөх үү? Бүгд л буудан алахыг шаардаж байгаа. Итгэцгээж байна уу? Яахаараа мань хүн итгэхгүй байх ёстой билээ? Айцгааж байна уу? мань хүн яагаад айж болохгүй гэж? Тэд нар амь, амьдралаа хамгаалж байна, мань хүн яасан гэж амь насаа хөнөөх билээ?

Үгүй ээ, тэглээ ч гэсэн мань хүн гараа өргөхгүй. Цуглаанаас зайлсхийхийг оролдоно. Ажилдаа явахгүй байх уу? Ажил таславал одоо шүүдэг болсон. Яаж ийгээд аргална. Эрт гараад явчихна, оройн найм болгож байж буцаж ирнэ.

Тэрээр ээлж эхлэхээс нэг цагийн өмнө бааз дээрээ ирэхэд, том хаалгаа онгойлгоо ч үгүй байв. Гэтэл ерөөсөө онгойлгосонгүй, замын хуудас ч бичиж өгөхгүй байгаа юм санж. Захиргааныхан, жолооч нар, засварын ажилчид гээд өглөөний ээлжийнхнийг бүгдийг баазын хашаан дотор цуглуулжээ.

Ачааны машины тэвшин дээр Чекин, Кирпичева хоёр гарчихсан, боловсон хүчний тэр хүүхэн цугларагсадыг өлөн нүдээр өрөмдөх мэт харж байна.

Чекин өчигдрийн мэдээ, бүгдэд буудан алах ял заасан өнөөдрийн шинэ мэдээ хоёрыг түгдрэн барин уншиж сонгов. Дараа нь “Правда” сонины “Фашистын тагнуулчдыг бут ниргэв” гэсэн тэргүүн өгүүллийг уншжээ.

Чекинийг энэ тухай уншиж байх хооронд Кирпичева тэр хоёрын аль нэг юм уу, эсвэл урьдаас үүрэг авсан нэг хүн Тухачевский болон бусад жанжныг буудан алахыг шаардсан тогтоолын төсөл санал болгох мөч улам бүр ойртон буйг Саша түгшүүрлэн бодож зогсов. Хэрвээ мань хүн “эсрэг” санал өгч гараа өргөвөл, тэр даруй “Дайсны хамсаатан Панкратовыг буруушаах тухай” хоёрдахь тогтоолыг батлаж, ДЯАК руу мань хүнийг аваад явна, тэгээд маргаашийн сонинд бичнэ, автобаазад ажилд яаж орсныг шалгаж эхлэнэ, ухсаар байгаад мужийн намын хороо руу, Михайлов, түүний туслах хоёр руу хүрчихнэ. Өөрийнхөө араас олон хүнийг

дагуулах нь. Үгүй ээ, “эсрэг” санал өгч болохгүй. Гэхдээ “төлөө” бас өгч болохгүй. Хэрвээ гараа өргөчих юм бол мань хүн өөрийгөө хэзээ ч өршөөхгүй. Тэгсэн хүн яаж амьд явах вэ?

Саша энгэрийнхээ халааснаас хайрцагтай тамхиа гаргаж, шүдэнзээ олов. Санал хураагаад эхлэнгүүт мань хүн хоёр гараараа хашиж байгаад тамхиа асаана, тийнхүү нүүрээ ч бас таглачихна.

Чекин сонингоо уншиж дуусаад,

-Нөхөр Барышников санал гаргана гэж хэлэв.

Үйлдвэрчний хорооны дарга Барышников “Нэгдүгээр автобаазын ажилчид бид...” гэж эхлээд буудан алахыг шаардсан товчхон тогтоол уншив.

-хэн дэмжиж байна? гэж Чекин асуув.

Бүгд гараа өргөцгөөв.

Саша тамхиа амандаа хийж, шүдэнзээ зураад, тамхиа хашин асааж сорлоо.

Дэргэд нь зогсож байсан Леонид хавирга руу нь гэнэтхэн нударлаа:

-Хөөе, чи яачив?

Саша гараа буулгаж эргэн тойрныг харвал бүгд гараа өргөжээ. Индэр рүү харлаа.

Чекин, Кирпичева, Барышников гурав яг түүн рүү ширтэж байв.

Саша гараа өргөлөө.

Цуглаан тарлаа. Засварынхан ажлынхаа байр руу, захиргааныхан өрөө өрөө рүүгээ явцгааж, машинууд ч шугамандаа гарч эхлэлээ. Саша ч замын хуудсаа бичүүлээд ажилдаа гарлаа.

Тэрээр өнөөдөр мебелийн фабрикт хуваарилагдаж, бэлэн ширээ, сандал төмөр замын ачааны буудал руу зөөв. Гараар ачдаг яарах юмгүй, тайван ажиллацгаана. Саша ч тэднийг шахсангүй. Тэр ч бүү хэл, бүхээгнээсээ ч гарсангүй. Жолоон дээрээ хоёр гараа зөрүүлж дэрлээд суугаад байлаа.

Өчигдөр мань хүн цахилгаанч Володя Артемкиныг дэмжээгүй, өнөөдөр бүх насаараа хүндэлж явсан, шүүх хурал ч ёсчлон болоогүй хүмүүсийг цаазлуулахын төлөө санал өглөө. Маргааш... Маргааш юу болох вэ? Яг л өнөөдрийнх шиг юм болох нь тодорхой байна. Всеволод Сергеевич зөв хэлж дээ, мань хүн арга буюу гар өргөлөө.

“Та заавал зад шүүмжилж, хэн нэгнийг ардын дайсан хэмээн босон харайж, нүүр рүү нь чичлэхгүй, та хүссэн, хүсээгүй бусдын аяыг дагахаас өөр аргагүй болно” гэж Всеволод Сергеевич ярьдаг сан. Яг л тэгж таарлаа. түүнийг албадаж нийтийн жагсаалд орууллаа. Хуучин “хэн бидэнтэй нэг биш байна, тэр бидний эсрэг байгаа” гэдэгт үнэн санаанаасаа итгэж, нийтийн жагсаалд сайн дураараа нийлэн жагсдаг байсан. Өнөөдөр тэгж бодохгүй байгаа хэрнээ бусдын жагсаалд нийлж, айсан, эмээсэн, хулчийсандаа, өндөгөөр чулуу хагалж болохгүй гэж өөрийгөө зөвтгөж санал өгч байна. Хүчтэй, хүчгүй бүгд нэг уяагаар хүлэгдчихэж. Зохиомол дайснаа харааж зүхсэн, өөрсдийнхөө алуурчдыг шагшин магтсан, дуу дуулсан, хашгирч гуугалсан олон сая хүнтэй орон гүрэн. Сүрэг нь галзуу хурдтай хуйлран давхиж байгаа учраас, хурдаа саасан нь гишгэчүүлж, зогссон нь няц даруулна. Урагшаа л давхиад байх хэрэгтэй, уушиг-ныхаа байгаа чадлаар, хоолой мэдэн бархирч явах хэрэгтэй, эс тэгвээс залхаан цээрлүүлэх илдэнд өртөнө, бусдаас юугаар ч ялгарч болохгүй, унасныгаа хайр найргүй гишгэчиж, урхидагчийн цалманд орсноосоо нүүр нүдгүй зулбаж явах хэрэгтэй. Тэгээд айдсаа дарахын тулд зогсоо чөлөөгүй бархираад байх хэрэгтэй. Тэр бархираан нь ялалтын марш, хангинасан дайчин дуунууд.

Одоо мань хүн энэ сүрэг дотор байраа эзлэлээ, одоо урагшаа хөл мэдэн харайлгаж, хоолой мэдэн бархирч, унасныг гишгэчиж, цаламдуулснаас тахал мэт зулбаж, айдсаа дарахын тулд хашгирч явахаас өөр замгүй боллоо.

Ачигч бүхээг рүү нь балбав.

-Хөөе, унтчихаа юу?! Аччихаад байна, бушуу явж буулга.

Орой нь диспетчер түүний замын хуудсыг авахдаа,

-Дөнгөж дөрөвхөн яваа юу? гээд толгой сэгсэрчээ.

-Ерөөсөө ачиж өгөхгүй юм.

-Акт бичихгүй яагаав?

-Тэд нар мөн гарын үсэг зурна даа?!

Гараашийн хашаан дотор Глеб зогсож байв. Тэрээр Сашаг машинаа угаалга руу оруулмагц түүн рүү очив.

-Сайн уу, ялдам аа!

-Сайн, чи сайн уу!

Саша бууж, цоргоо нээгээд, урт хоолойг өргөж, машиныхаа тэвшийг шүршив.

-Өнөөдөр юу хийх вэ? гэж Глеб асуув.

-Юу ч хийхгүй.

-Нэг газар орж, жаахан суух уу?

-Ядраад байна, эртхэн хажуулахаас.

-Ганц, ганц хундага юм тогтооё л доо.

-Мөнгө байхгүй.

-Надад байна.

Глеб хааяа өөрийгөө даах нь бий, харин хүний өмнөөс төлнө гэдэг ном байхгүй.

-Банкнаас хүү аваа юу?

-Яг тэглээ.

-Хаачихав?

-“Селигер” рүү зүгээр байх.

Саша түүн рүү гайхшран харав. “Селигер” бол мундаг үнэтэй, энэ хотын ганц жинхэнэ ресторан билээ.

-Савхин гуталтай намайг оруулах юм уу?

-Надтай бол хөл нүцгэн ч оруулна.

-Яагаад тэр билээ?

-Тэгэх учир бий.

Глеб өнөөдөр инээж барих ч үгүй, бодол болсон царайтай байвч архи уух гэж хорхойсч буй нь харцнаас нь илт байна.

Нэг шил архи захиалцгаалаа.

-Эднийх задгай хуушуур сайхан хийдэг юм, хоолныхоо нэр төрлийг нэмэгдүүлэх үүднээс үзвэл яасан юм гэж Глеб санал болгов.

-Чиний хэлснээр л больё.

Эднийхэн Глебийг, үнэхээр, мэдэж байна.

-Би энд ажиллаж байсан юм, найрал хөгжимд төгөлдөр хууран дээр сууна, орой болгон ажилтайгаас нь залхаад гарчихсан юм гэж Глеб тайлбарлав.

Эхний хундагаа ууж, зуушаар даруулцгаав.

-Людмила руу очиж байна уу?

-Ойрд харсангүй.

-Яагаад?

Саша дал мөрөө хавчив.

-“Яагаад” гэж юу гэсэн үг вэ? Ая нь тэгж таарах юм. Оройн хоол идэх гэж кафед очвол харна, үгүй бол харахгүй.

-Сайн хүүхэн дээ, нүгэлтэй үнэнч, чамд яггүй унасан шүү. Гэхдээ эр хүний яриа ярих уу? гээд Глеб Саша руу харав.

-Ярилгүй яхав.

-Тэр чинь нэг хүнтэй, мэдэв үү... Москвад. Мундаг дарга. Авгайгаасаа салаад, байраа сольцгоож байгаа юм, сольчихонгуутаа Людкаг Москва руу татаж авна. Людкад сайхан ирээдүй байна, ойлгож байна уу?

-Өө, тийм үү, юун сайн юм бэ, би өмнөөс нь баяртай байна гэж Саша чин санаанаасаа хэлэв.

мань хүн Людкагийн өмнөөс, үнэхээр, баяртай байж.

Москвад олны дунд бараа тасрахад амар. Гэхдээ энэ тухай Сашад өөрөө яривал болох л байсан даа.

-Чи намайг хэлсэн гэж болохгүй шүү гэж Глеб анхааруулав.

-Тохирлоо. Би ч бас чамд үнэнээ хэлэхэд, түүний өмнөөс би үнэхээр баяртай байна.

-Гэхдээ цаадах чинь чамд сайн шүү, зүгээр эр хүн гэдгээр биш, сэтгээлээсээ сайн гэж Глеб хоёр биендээ архи хундгалангаа хэлэв.

-Чи яагаад тэгж бодож байна?

-Анзаарахгүй юү.

-Нээрэн, бид хоёрын харьцаа сайн шүү гэж Саша өгүүлэв.

-түүний найз Лизаг мэдэх үү?

-Юун Лиза билээ?

-Сэргийлэхэд ажилладаг гэл үү дээ.

-Ёстой мэдэх юм алга.

Паспортын Елизаветын тухай яагаад гэнэт яриа сэдэв, энэ асуултын цаана юу байна, санаатай асуув уу, санамсаргүй асуув уу?

Глеб хажуугийн хаалга руу эргэж харав. Тэндээс цагаан цамцтай, хар эрвээхэй зангиатай, хар өмдтэй, лакдмал хар шаахайтай, гурван хөгжимчин гарч ирлээ. Тэд нар Глебийг хараад найрсаар толгой дохин мэндэлцгээв.

-Хамт ажиллаж байсан нөхөд, Беня, Семен, Андрей гээд Глеб мушилзав. -Сайн залуус, даанч энэнээс болсон юм хэмээн мань хүн лонх руу заав.

Хажуугийн нөгөө хаалганаас урт өмсгөлтэй, шар үстэй, биерхүү, будмал хүүхэн гарч, инээмсэглэсээр тайз руу очив. Хүмүүс түүнийг алга ташин угтав. Хүүхэн инээмсэглэсэн янзаараа мэхийн ёслож, танхим руу агаарын үнсэлт илгээлээ.

-Уул нь хоолойтой байсан юм... Архинд шимтэхгүй ч гэсэн үнэрлэхээс буцахгүй. Одоохондоо ресторанд тэсч байна, удахгүй аль нэг найрал дуучдын газар очих байх.

Хөгжимчид “Хөгжилтэй залуус” киноны дууг дарлаа: “Хөгжилтэй дуунд сэтгэл цэнгэнэ...” Саша энэ дууг хэдийн мэддэг болсон, орчин үеийн бусад дууг ч мэддэг болсон. “Тийм киноны тэрний дуу” гээд л радиогоор байнга сонсоно. Мозгонад байх хооронд нь гарсан бүх киног үзэж амжсан: “Максимын идэр нас”, “Гурван нөхөр”, “Сүүлчийн хот айл”, “Эрэлхэг долоо”, “Цирк”, “Ахмад Грантын хүүхдүүд”, “Аз жаргалын эрэлчид”, түүнээс гадна “Инжгүй хүүхэн”, “Максим эргэж ирсэн нь” гэдэг шинэ кинонуудыг бас үзсэн. Гэтэл түүний мэдэхгүй бүх дуу киноных байсныг яана. Одоо бол ийм юмаар бүдрэхгүй.

Ресторан тэр аяараа шуугиж, хүмүүс фокстрот, танго бүжиглэж байна. Барагтайхан бүжиглэж байгаа ч хөгжим тасралтгүй тоглож байна.

Глеб зөөлөн давсалсан хэмх захиалж авчруулав.

-За алив, чи өнөөдөр нэг л бүрзгэр байх чинь гээд Глеб хундагаа барив.

-Би юү? Харин чи л нэг юманд санаа зовоод байх шиг санагдах юм гэж Саша зөрөв.

Глеб өнөө орой анх удаагаа инээв:

-За, Сашка, мэдэн будилахаа больцгооё. Надад нэг санал байна: Миний бүжиг дэглэгч Семен Григорьевич орон нутаг руу, Азийн аль нэг зүгт, уугуул үндэстнийг гэгээрүүлэхээр явах гэж байна. Намайг төгөлдөр хуурч, баян хуурчаар урьсан, дахиад нэг туслах хэрэгтэй. Чи явахгүй юү?

-Сонин хэрэг байна, ёстой толгойд ороогүй зүйл чинь энэ гэж Саша өгүүлэв.

-Бод л доо!

-Тэр туслах чинь бүсгүй хүн байх ёстой байлгүй.

-Бүсгүй туслах байгаа. Концертын товчооны томилолтоор албан ёсоор явах юм. мань хүн тэнд танилтай, тэр товчоонд зохих ном журмын дагуу шимтгэл суутгалыг нь төлнө. Паспортонд хүртэл концертын товчоонд бүртгэлтэй гэсэн тэмдэглэл хийнэ. Ухаарч байна уу, ялдам аа?

Саша бодлогошров. Аль нэг зүгт явж, гол гаталгагчаар ч хамаагүй ажиллах юм сан гэж бодож асан, гэтэл бүр чөлөөтэй, эрх дураараа ажил яригдаж байна. Гэхдээ гаталгагч бол ажил, хар бор ч гэсэн ариун цагаан хөдөлмөрөөр талхныхаа мөнгийг олно, одоо ч тэгж амьдарч байна. Бүжиг энэ тэр бол мэхлэлт, Семен Григорьевич мэтийн зальтнууд учир мэдэхгүй амьтдыг мэхлэж, мөнгө халааслаж байгаа юм. Уул нь мань хүн автобаазад урхинд байгаа, гэтэл энэ бүжигчдийн дунд боловсон хүчний шалгалт хийхгүй гэж үү, тэднийг бас элдэв хурал цуглаанд хөөж оруулдаг байлгүй. Өөр шиг нь хүн нэг газар удах бол аюултай, гэхдээ одоохондоо чичлээд байгаа юм алга. Нөгөөтэйгүүр, Калининаас явах боллоо гэхэд, өөр хотод очоод ажилд орох болвол жолооч байсан, одоо жолооч хийх гэж байна гэхэд хэнд ч ойлгомжтой. Барууны бүжгийн багшийн туслах байсан гээд автобаазад ажилд орох гэж очих уу? Инээдэмтэй хэрэг!

Өнөөдөр өглөө цуглаан дээр гар өргөснөөр мань хүн хувь заяаныхаа эрхшээлд нэгэнт орсон. Амьдралынх нь ийм л үе эхэлчихээд байна. Эсэргүүцээд нэмэргүй. Ажил хийлгээд байвал сайн хэрэг, дахиад шоронд хийвэл тэр л биз, суух л болно. түүнийг хуга нугалжээ! Тийм учраас хэрж тэнэж явахын хэрэг байхгүй, тэртэй тэргүй барьж аваад, туулай шиг толгойгоор чинь газар савчихна.

-Үгүй ээ, Глеб, тэр чинь надад зохихгүй. Мэргэжил байна, ажил байна, хаашаа, ямар уугуул үндэстэн рүү харайж явах билээ? гэж Саша өгүүлэв.

-Калинин сайхан байна уу? гээд Глеб малилзан инээмсэглэв.

-Сайхан байна, юу нь муудахав. Сайхан хот.

-Боль доо, Саша. Надтай тэгж яриад яахав... “Сайхан хот”... Москва дор юм уу?

Саша түүн рүү эгцлэн харав:

-Чи юу хэлэх гээд байна?

-За, бид нар найз юм уу, биш юм уу? Чи чинь “хар данстай” шүү дээ.

-хэн хэлээв?

-Ямар ялгаа байна? Леонид хэлсэн юм.

Саша тавагнаасаа нэг шарсан төмс сэрээдэж авав.

-Тэгж саная л даа, тэгээд юу гэж?

Саша тэгж хэлчихээд цочих шиг болов. “Хар данстай” учраас түүнийг эндээс алга болохыг Глеб санал болгож байна. Энэ тов тодорхой. Яагаад гэнэт ингэв? Леонидын даалгаврыг биелүүлж байна уу? Хэрвээ Сашаг бариад авбал, Леонидоос зүүгдчихнэ. мань хүн түүнийг автобаазад оруулсан, ажилд авна гэж зүтгэсэн, одоо болохоор мөрөө баллах гэж өөрийг нь нүднээсээ далд оруулах гээ юү?

-Тэгээд юу гэж? гэж Саша дахин асуув. -Би “хар данстайдаа” яачихаав? “Хар данстай” нь ганц би биш. Над шиг хүн Калининд замаас аваад захаа хүртэл байна.

-Ялдам аа, чи яагаад шал дэмий юманд уурлачихав? хэмээн Глеб инээмсэглэв. -Чи ял эдлэж явсан хүн, чамайг өнөөдөр ажиллуулж байна, маргааш хөөж л орхино. Чи “хар данстай” хүн, Калинин өнөөдөр тусгай дэглэмгүй хот, маргааш гэхэд дэглэмтэй л болчихно. Тэгвэл би чамд арай чөлөөтэй амьдралыг санал болгож байна шүү дээ.

-Яг чам шиг үү?

-Тиймэрхүү гэх үү. Чи ямар зураг зурах биш... Төгөлдөр хуур дарах биш... Тийм ээ, надархуу, одоо бүжгээр яаж их мөнгө олдог гэж бодно, бурхан өршөө!

-Тэгээд та нар хэзээ явах гэж байгаа юм бэ?

-Гурав хоногийн дараа.

-Чухам хаашаа тэр вэ?

-Одоохондоо яг шийдээгүй байна гэж Глеб зувчуулсхийв.

Саша гэнэтхэн нэг зүйл таамаглав.

-Чи бас “хар данстай” юу? гэж Тэрээр шууд асуув.

-Чи яагаад тэгж бодов?

-Чи яаж байгаад “хар данс” авчихсан юм бэ?

-Чи юу гээд наалдчихав аа?! гэж Глеб дургүйцэв. -Тэгвэл Семен Григорьевичийг “хар данстай” гэж бодож байна уу, түүний туслах Ноннаг бас тэгж бодож байна уу? Мөнгө олохоор явах гэж байвал л “хар данстай” байдаг юм уу? Сашка, чи сонин гайхал байна шүү! гээд Глеб дахин инээмсэглэв.

-Дансгүй бол тэр л биз хэмээн Саша гараа сэгсрэв. -Харин би хаашаа ч явахгүй. Алив, энийгээ гүйцээе.

Тэр хоёр лонхтой юмаа гүйцээж уув. Тооцоогоо бодууллаа. Саша талыг нь төлөв. Глеб ч дургүйцсэнгүй.

Глеб бурагч, донгосогч, тэглээ ч гэсэн Леонид түүнд чухам юу хэлснийг мэдвэл зүгээрсэн.

Нэг шалтаг олдлоо.

Тав, зургадугаар сарын гавшгайчуулын нэрсийн жагсаалтыг хүндэт самбарт хадсан байв. Сашагийн нэр дахиад алга байсан тул Тэрээр Леонидоос,

-Би яагаад байхгүй байна? гэж шууд асуув.

-Ойлгохгүй байна гэж үү?

-Хөөе, Леня, би эндээс гарсан нь шулуун юм уу? гэж хэлээд Саша түүний царайг сонжих мэт харав. Хэдийгээр баргар царайлж байвч зарим нэг санааг нь гадарлаж болохоор мэт.

-Гарах ий? хэмээн Леонид нүдээ томсгон, хүндэт самбар руу дохиж, -Үүнээс болж уу? Энэ чамд хэрэгтэй юм уу? гэв.

-Гадуурхаад байна, ойлгож байна уу? Туйпуунд хөөхөөс өөр олигтой ажил ч өгөхгүй байна.

Леонид дал мөрөө хавчив:

-Тэр тухайд чи л толгойгоо ажиллуулах ёстой, хэрэгтэй хүнтэй өөрөө тохиролцох ёстой. Гадуурхах?! гээд Тэрээр инээв. -Больж үз! Учир нь олодоно. Харин гарах тухайд?.. Шинэ газар очвол дээрдэнэ гэж бодож байна уу? Яг адилхан гэж мэд.

Чин сэтгэлээсээ ярьж байна. Глебт ямар ч үүрэг өгөөгүй байх нь. Тэр яриаг Глеб өөрөө санаачилж, Семен Григорьевичид элсүүлэх гэсэндээ л тэгж элдэвлэж. Явж явж гахай юм даа! Зүгээр л хэлбэл болоо биз, заавал “хар дансаар” далимдуулах хэрэг юу байна. Найз гээд байгаа шүү, бас! Үгүй, өөр эх сурвалжаас элдэв зүйл мэдээ юм болов уу? Людаг асуусан, паспортын хүүхнийг асуусан. Хэрвээ Сашад ямар нэг аюул нүүрлэсэн бол Люда хамгаас түрүүнд сануулах ёстой сон. Глебийн л санаачилга. Тэд нарт т у с л а х гэгч хүн хэрэг болчихоод мань эр Сашаг ятгах гэж үзэж.

Саша дахиад туйпуу зөөв. Түрүүн төлөвлөгөө биелүүлээгүй гээд мебелийн үйлдвэр рүү явуулсангүй.

Диспетчер хэд явсныг нь тоолж замын хуудсанд нь гарын үсэг зураад, Сашад нэг цэнхэр цаас өгөв.

-Чинийх.

Тэр нь маргааш өглөө есөн цагт суугаа газрынхаа харьяа сэргийлэх дээр паспорттойгоо очихыг тушаасан зарлан дуудах ажээ.

Зам тээврийн ямар ч хэрэгт холбогдоогүй, хөдөлгөөний дүрмийн зөрчил ч байхгүй дээ.

Зөрчил байж гэмээ нь замын цагдаагийн газар руу л дуудна.

-Энэ чинь юу вэ? Яах гээ юм бол?

-Би яаж мэдэхэв, сэргийлэхээс ирж, дэвтэрт гарын үсэг зуруулж байж өгчихөөд л явна лээ гэж диспетчер өчив.

-Ажлаасаа хоцроно шүү дээ.

-Яая гэхэв? Ямар нэг дайчилгаа ч юмсан уу? Өдийд ч ямар дайчилгаа байхав? Тариалалт дуусчихсан. Хураах цаг болоогүй.

Гэртээ иртэл яг тийм зарлан дуудах хүлээж байж.

-Хэсгийн цагдаа ирж, наадахийг чинь үлдээсэн, тушаал өгч, дэвтэрт гарын үсэг зуруулсан. Ууж барьдаггүй, томоотой залуу юм сан, ямар хэрэг тарьчихаав гэж асуусан чинь, ер нь та нар уух биш, та нарыгаа би мэдэлгүй яахав. Маргааш яг ес гэхэд паспорттой нь очуулаарай гэсэн хэмээн эмгэн тайлбарлав.

Юм хумаа эмхэлдэг юм бил үү? Юмыг яаж мэдэхэв. Гэтэл юм нь юу байж болохов? Баривчлах гэсэн бол наашаа ирмээр. Танилын нүүрээр паспорт авсныг мэдчихээд Елизаветаг хэрэгт татаа юм болов уу? Юу л бол... Тэгсэн бол Люда мэдмээрсэн.

Өнөөдөр, нэн даруй яваад өгөх үү? Шинэ газар очтол шинэ зовлон гараад ирнэ: Түрүүчийн ажлын газрын чинь тодорхойлолт хаа байна? Чөлөөлөгдсөн тухай тэмдэглэл хаа байна, оршин суугаа газраасаа хасуулсан тэмдэглэл хаа байна? Сэжигтэй бичиг баримт! Ийм паспортоор хаяг бүртгэж ч болохгүй, ажилд авч ч болохгүй.

Зөвлөлтийн хүн энэ элдэв цаас, тодорхойлолт, бичиг баримтаар ямар муухай хүлэгдсэн юм бэ! Хаашаа ч хөдлөх арга алга!

За яахав, сэргийлэх рүү очихоос. Юу л болвол болог.

Сашагаас олон хүн түрүүлж ирээд, гадаа үүдэнд, дотор хонгилд шахцалдан байх ажээ. Тэгсэн чинь Калинин хотод паспортын дэглэм тогтоож, паспортын хязгаарлалттай хүмүүс хорин дөрвөн цагийн дотор хотоос гарч явах ёстой болчихоод байгаа юм байж. Зөвхөн нэг районд ийм олон шүүгдэж явсан хүн байсныг хараад Саша бүр гайхжээ. Овгийн үсгээр нь А-Ж, З-О, П-Я гэж ялгасан гурван оочер байна. Саша өөрийнхөө оочерт орж, цаг гаруй зогсож байж, цагдаа нар суусан хашлага руу хүрэв.

Дэслэгч Сашагийн паспортыг шалгаж үзээд, “Бүртгэв” гэсэн тэмдэглэлийн дор “Хасав” гэсэн тэмдэг дараад, нэрсийнхээ жагсаалтаас түүний овгийг олж өмнө нь зураад,

-Гарын үсгээ зур! гэв.

Хүмүүс араас нь шахаад бэрх. Саша “Калинин хотоос явах тухай анхааруулга” гэснийг дөнгөж харж амжаад, нэрийнхээ ард гарын үсгээ зурав.

-Ажлынхаа газар очиж тооцоо хий. Калинин хотоос явж буйн учир халагдана. Баазын захиргаа мэдэж байгаа. Хорин дөрвөн цагийн дотор яваагүй бол эрүүгийн хариуцлага хүлээнэ шүү. Дараачийнх нь!

Саша сэргийлэхээс гараад ажил дээрээ ирэв. Цаадуул нь үнэхээр мэдэж байв. Тойрох хуудсаа авлаа. Гарааш руу очиж машинаа механик Хомутовт тушаалаа. Хомутов машиныг нь шалгаж үзэлгүй тойрох хуудсанд нь гарын үсэг зурж өгөөд,

-Чи манайд даанч удсангүй гэж өгүүлжээ.

-Харин тэгж таарлаа.

Нярав, диспетчер хоёр гарын үсэг зурлаа, замын хуудас, бүх бичиг баримтаа тушаачихсан учир асуудал алга, харилцан туслах касснаас зээл авч байгаагүй учраас үйлдвэрчний хорооныхон ч төвөггүй гарын үсгээ зурцгаав. Леонид энэ бүхнийг нотлож эцэст нь гарын үсэг зураад,

-Одоо хаачдаг болж байна? гэж урамгүй асуув.

-Хараахан мэдэхгүй байна.

Саша тойрох хуудсаа санхүүд буцааж өгөв. түүний цалин далан найман рубль хорин дөрвөн мөнгө, эдлээгүй амралтын мөнгө хорин есөн рубль хорин гурван мөнгө болсныг тоо ёсоор гардаж авлаа. Нарийн бичгийн дарга паспортонд нь “тэдний өдөр халагдсан” гэсэн тэмдэг дарж, Саша тус баазад жолоочийн албан тушаалд ажиллаж байсан, арга хэмжээ авагдаж байгаагүй, Калинин хотоос явж буй учир халагдав гэсэн тодорхойлолт дор нь машиндаж өглөө.

Нарийн бичгийн дарга тодорхойлолт өгөхдөө түүн рүү харсангүй. Ер нь өнөөдөр бааз дээр нь тааралдсан хэн ч бай түүний өөдөөс эгцэлж харсангүй. Зөвхөн механик Хомутов, “Чи манайд даанч удсангүй” гэж хэлсэн, бас Леонид “Одоо хаачдаг болж байна?” гэж асуусан. Бусад нь хүний урманд ганц үг хэлсэнгүй.

Саша автобаазаас шууд Глебийнхнийг зүглэв. Хаалгыг нь зөндөө цохьсон боловч хэн ч байдаггүй. Хашаанаас нь зүүгдэн өнгийн харвал эгч нь ногооныхоо газар юмхан оролдож байна.

Саша түүнийг дуудаж, Глеб хаа байгааг асуув.

Авгай нүдээ онийлгон түүн рүү харснаа,

-Глеб байхгүй ээ. Яваад өгсөн гэв.

-Хаашаа?

-Мэдэхгүй. Ленинград явсан уу, өөр тийшээ ч магадгүй. Мэдэхгүй. Захиа бичнэ л гэж хэлсэн.

-Баян хуураа аваад явсан уу?

-Баян... хэмээн авгай түгдрэв. -Тэгсэн, авсан... тэгсэн байх аа.

За, ингээд Глеб Семен Григорьевичтэй арилаад өгч.

Глеб яагаад явья гээд байсныг Саша сая л ойлголоо. “Калинин өнөөдөр тусгай дэглэмгүй хот, маргааш гэхэд дэглэмтэй л болчихно” гээд байсан, паспортын дэглэм тогтоох гэж байсны үнэрийг ямар нэг аргаар авчихсан байж дээ. Яагаад шууд хэлсэнгүй вэ? Яагаад гэвэл тийм юмыг ярьдаггүй шүү дээ. Глеб ийм юм мэдэж байгааг дотоодыг хамгаалахынхан шиншилчихвэл, энэ мэдээг хэнээс дуулсныг хэлүүлэхээс нааш тавихгүй. “Хар данстнуудыг” гэнэдүүлэхийн тулд, хотыг нэг амьсгаагаар цэвэрлэхийн тулд энэ үйлдлийг нууцаар бэлтгэж таараа. Глебт хэн нэгэн анхааруулсан хэрэг, мань хүн, мэдээж, хэнд ч хэлэхгүй гэж ам өчгөө өгсөн байж таарна, тийм учраас Сашад хэлсэнгүй, гэхдээ ойлгуулсан байна. Тэгээд хөөгдөж гарахгүйн тулд өөрөө арилаад өгч. Энэ бол өөрөө “хар данстай” гэсэн үг. Улайдаггүй байсан. Яаж ч согтлоо гэсэн амаа барьж чаддаг байж.

түүний саналыг хүлээж аваагүйдээ Саша одоо харамсав. Ажлаас халагдах бичиг баримт бүрдүүлэхэд цаг хэрэгтэй учир Саша тэдэнтэй явж амжихгүй байсан, гэхдээ араас нь яваад очихгүй юу, наад зах нь хаягий нь мэдэж байх байсан, хэдийгээр барууны бүжгийн багшийн туслах ч гэсэн эхэн үестээ ажилтай байх байсан.

Харин одоо хаачих вэ? Дахиад хэрэн тэнэх нь.

Саша гэр рүүгээ буцах зуур иймэрхүү юм бодож явав. Тэрээр энэ хотод онцгой баярлах юм үзээгүй ч, орох оромжтой, толгой хоргодох газартай, ажилтай болсон. Энд бас аз нь түшиж, Люда, Леонид, Михайлов зэрэг хүмүүстэй таарсан, паспорттой, хаягийн бүртгэлтэй, үйлдвэрчний батлахтай болсон. Энэ бүхэн бол чөлөөт хүний өвөрт байх ёстой зайлшгүй зүйлс.

Дотоодыг хамгаалахынханд талархах хэрэгтэй, хэдэн сар амсхийлгэлээ, одоо дахиад эхнээс нь эхлэх хэрэгтэй, цаашаа сажлаад бай гэж байна аа даа, ээ мөн чөтгөрүүд шүү! Хаашаа явах вэ? Рязань руу явах нь мөн байх. Михаил Юрьевичийн дүү тэнд байгаа, дэм тус үзүүлж мэднэ. Өглөөний галт тэргээр Москва руу гарч очингуут Казанийн буудал дээрээс Рязань руу хөдлөнө.

Ээж рүүгээ утасдахаа одоо хэр азная. Эндээс утасдахгүй, Москвагаас ч хэрэггүй, хий зовоогоод яахав. Рязаниас л утасдана, шилжээд ирсэн, энд дээр байна, бүх юм болж байна гэж хэлнэ.

Саша гэртээ ирээд, маргааш бүрмөсөн явах болсноо эзэгтэйд хэлэв.

-За, юу болчих нь тэр вэ? гэж эзэгтэй асуув.

-Өөр ажилд шилжиж байна. Би танд өргүй биз дээ?

Эмгэн уруулаа тамшаалж,

-Нэгэн хүртэл төлсөн шиг билээ гэв.

-Тэгвэл тооцоо гүйцсэн юм байна.

Саша чемодан, үүргэвч хоёроо төхөөрлөө. Элдэв юм нэмэгдчихэж. Сүртэй юм худалдаж аваагүй хэрнээ өвлийнх нь хувцас хунараар чемадон нь дүүрчихлээ. Хар зах дээрээс хямдхан үүргэвч авсан нь л яамай. Цагаан даавуу, дэрний уут, угаагаагүй дотуур хувцас энэ тэрээ тийш нь хумьж чихэв. Бас ч гэж аж төрнө гэж бодож байсан болохоор хэрхэндээ элдэв новш хуримталчихаж. Санаснаар болсонгүй. Рязаньд бас санаснаар болохгүй байх, тэгээд л нэг хотоос нөгөөд хөөгддөг ажилтай болно. Шилэн аяга, таваг бас бус аар саар юмаа хоёр хөгшинд орхихоор болов. Ширээний шургуулгыг шалгалаа, орон доогуур шагайлаа, юмаа эмхэлчихэв боллолтой. Ширээн дээр зөвхөн саван, сойз, сахлын хэрэгсэл байна, өглөө амжиж нүүр гараа угааж, сахлаа хусах хэрэгтэй.

Гадаа нар жаргаагүй ч оройн найман цаг дөхөж байгаа болохоор

эдний зоорь шиг байранд бүрэнхий оргиж, асаасан чийдэн сүүтийн байна.

Одоо Егорыч ажлаасаа ирнэ, тэр хоёр салахын өмнө хугас шил юм хувааж ууна, тэгээд тэдний сэрүүлгийг гуйж, таван цаг дээр тааруулна, зургаа гэхэд галт тэрэгний буудал руу амжиж очно.

Шат хужигнан, хаалга нээгдэж, түргэн алхах чимээ сонсдов. Лав л гэрийн эздийн хөл биш. түүний өрөөний хаалгыг орлодог даавуун хөшиг нээгдэж Люда ороод ирэх нь тэр.

-За, сайн уу, яагаад зогсоод байна, наашаа суу гэж Саша хэнэггүй өгүүлэв.

Люда төмөр ор руу очиж Сашатай зэрэгцэн суугаад, түүн рүү эргэж, чимээгүй хэсэг харав.

-Юуг нь хараав? Ойрд харсангүй юү? гэж Саша нөгөө л хэнэггүй байдлаараа асуув.

-Хэзээ явах гэж байна?

-Маргааш найман цагт, Москвагийн суудлаар.

-Хаашаа?

Саша дал мөрөө хавчив:

-Эхлээд Москва руу, хаачихаа галт тэргэнд шийднэ, Рязань явж магадгүй.

-Елизавета заяагүй новш, надад урьдчилж хэлсэнгүй.

-Хэлсэн бол яах гэж? Юу өөрчлөгдөхөв? Бичиг баримтаа бүрдүүлэхгүй, арай эрт л эндээс явна биз. Шинэ газар бүр дор юм болно шүү дээ.

-Тэр ч тийм шүү хэмээн Люда зөвшөөрөв.

Люда түүн рүү ойртосхийж толгойг нь илэхэд, бүрэнхийд танил үнэр сэнхийлээ.

-Зовсон ч амьтан бол доо, дахиад л хэрэн тэнүүчлэх нь гээд Люда гараа толгойноос нь авав. - Егорыч өглөө, “Манай хүнийг сэргийлэх дуудсан” гэж хэлсэн юм. Би эхлээд жолооч хүний л явдал биз гэж бодсон. Тэгсэн чинь паспорт нь чинийх шиг тэмдэгтэй манай гал тогоонд ажилладаг нэг хүн ажилдаа ирсэнгүй. Тэгтэл арван хоёрын үед ирээд, “Би явлаа, халагдая” гэдэг байна. Юу, яасныг тэгээд л мэдэж авцгаахгүй юү. Би чам руу жирийгээд ирсэн чинь чи гэртээ алга. Лизка руу, ажил руу нь тавиад хүрлээ, тэнд хөл тавих зай алга. Мөн олон хүнийг явуулж байна шүү.

-Бид ч олуулаа шүү хэмээн Саша инээв.

-Михайлов хэдийн алга болсон гэж Люда санаандгүй хэлэв.

-Ямар?! Мужийн намын хорооны дарга уу?

-Тийм ээ. Баруун солгойгүй барьж байна, тийм учраас чиний явж байгаа нь ч дээр байж магадгүй.

-Магадгүй... Чиний бусад танилыг хөндөөгүй юү?

-Үгүй ээ... Ангелинаг хэлж байна уу? түүний чинь паспорт цэвэрхэн. Гучин дөрвөн онд Москва, Ленинградад паспорт олгоогүй хүмүүс эндээс элдэв янзын тэмдэглэлгүй, цэвэрхэн паспорт авцгаасан юм гээд Люда санаа алдав.

-Тийм ээ, би мэднэ.

-Тийм тохиолдол зөндөө бий, жишээ нь, Глеб Дубинин, мань хүнийг гучин гурван онд Ленинградаас туусан юм.

-Глебийг үү? Яасан гэж?

-Ээж нь санваартны гэл үү, язгууртны гэл үү, удамтай юм гэсэн. мань хүн бас эндээс паспорт авсан юм.

-Яах гээд явчихав?

-Мөнгө олох л гэж. Би Ганнатай таарсан юм, тэгсэн чинь, “Семен Григорьевич тэр хоёр Уфа явчихсан, түрийвчээ түнтийлгэж аваад буцаж ирнэ” гэж байна лээ.

Уфа! Тэнд чинь бас Вера эгчийн хамаатан байгаа. Вера түүнд хэдийн мэдэгдчихсэн байгаа.

-Тэд нар яг Уфа руу явсан уу?

-Яг. “Надад Уфа, Төв шуудан, өөрөө хүлээн авагч” гэж бичээрэй гэж Ганнад хэлсэн байна лээ.

Эгч авгайгаа муудах вий гэж санаа нь зовоод байхгүй юү. Тэгээд л Ганнад, “Заримдаа очиж биеийг нь асууж байгаарай, элдэв юм болвол цахилгаан өгөөрэй” гэж тушааж байгаа нь тэр.

Тэр хоёр чимээгүй суузнав. Люда гарт нь хүрснээ атгаж авав.

-Чи надад гомдоогүй биз дээ?

-Яасан гэж? Яалаа гэж би чамд гомдох вэ дээ? Яг эсрэг шүү!

Тэрээр шал руу гөлрөн сонсож байснаа толгойгоо өргөн,

-Надад... хэмээн түгдрэв. -Чамд яаж хэлэхээ ч мэдэхгүй байна... Товчдоо, надад нэг хүн бий, надад хайртай, сайн хүн. Удахгүй түүнийгээ бараадахаар Москва руу явна. Надад итгэдэг хүн, би ч хүндэлдэг юм, түүнийг яаж хуурахав. Чамтай... Чамтай бол шал өөр. Чи тэр орой кафед миний зүрхийг зүсчихсэн, анхны оройг санаж байна уу? Ангелинагийн очоод, чамайг хорихоос гарсныг ойлгомгоц, биеэ барьж, над шиг хүн ийм хүнтэй холбогдох эрх байхгүй гэж дотроо шийдсэн. Тэгснээ дараа нь Леонидын машинаар явж байхдаа, чамайг гэр ч байхгүй, ажил ч байхгүй, одоо хаашаа явахаа ч мэдэхгүй байна гэж дахин бодмогц тэсээгүй юм. Бурхан намайг хэзээ ч өршөөхгүй гэж бодсон. Саша, би чамаар өөрийгөө бурхны өмнө зөвтгөх гэсэн юм. Би орох оронгүй зовсон хүнийг гудамжинд орхиогүй, тийм учраас эцгийг нь булааж, хүүхэд өнчрүүлсэн намайг бурхан өршөөнө, би өөрөө эцэггүй өсч бойжсон, эцэггүй өсч бойжно гэдэг их тусгүй шүү, Саша. Гэтэл би түүнийг булааж байна.

Люда гараа татаж, халааснаасаа алчуураа гаргаж нулимсаа арчив.

-Би сэтгэл уймраад байна, чи битгий тоогоорой. Чамайг өрөвдөөд байх юм... Чамайг ажилд ороод, байртай болчихонгуут, за ингээд гүйцээ! гэж шийдсэн юм. Илүү юманд санаархах эрх байхгүй. Чи надад үнэхээр сайхан санагдсан, өөр ч бас... Тэглээ ч гэсэн надад итгэдэг тэр хүнийг би хуурах ёсгүй... Гэтэл өнөөдөр юу болсныг сонсонгуут, хамаг ажлаа хаячихаад, наашаа харайлгаж ирсэн, чамайг яаж авардаг билээ л гэж бодоод байлаа...

Энэ удаа Саша түүний гарыг атгав.

-Чамайг ирсэнд би баяртай байна, уулзаагүй бол би хожим харамсах байсан. Чи надад маш их тус болсон, би тэр тухай ч хэлж амжаагүй яваа. Чамгүй бол би балрах байсан гээд Саша түүн рүү эгцлэн харав. -Тэгээд ч юм уу, чухамхүү чамайг аз жаргалтай яваасай, амьдрал чиний ачийг хариулаасай гэж би хүсэхийн цаагуур хүсч байна. Зүрхний угаас, чин санаанаасаа хэлж байна шүү.

Люда дахиад нулимс унагаж, дахин арчив.

-Баярлалаа, Саша, сэтгэлийн сайхан үгэнд чинь баярлалаа. Чамайг ч гэсэн аз түшиж яваг... гээд алчуураа далд хийв. -За, алив, хагацахын өмнө үнсэлцье.

Тэрээр босч, Сашагийн уруулыг озож үнсээд, толгойг нь хоёр гартаа удаан барьж нүд рүү нь ширтэн зогсов.

Тэгснээ гараа буулгав.

-Гүйцээ! Үүрд баяртай, Саша, муу юм бүү санаарай. Аз жаргалтай яваарай!

Тэгээд гэнэт орж ирсэн шигээ алга болж одлоо.

Галт тэрэг Ленинградын буудал дээр ирэв.

Эндээс ээж нь таван сарын өмнө түүнийг Калинин руу гаргаж өгсөн билээ. Одоо Калинины явдал дуусаад мань хүн дахиад энд ирчихсэн байна. Уфад түүнийг юу хүлээж байгаа бол? Уфагийн дараа юу болдог бол?

Саша талбайг хөндлөн гарлаа. Наранд халсан замын барагшин хамар цоргиж байна. Хүүхэд ахуйгаас танил дасал болсон Москвагийн гудамжны үнэр. Гэнэтхэн, одоо ингээд Варятай тааралдах юм шиг санагдаад явчихлаа. Хувь заяанд гайхамшиг тохиож болно шүү дээ! Тэрээр холхисон олныг харж, бүсгүйчүүдийн царайг тогтосхийн ажиглавч, яльгүй төстэй гэхээр нэг ч хүн олж харсангүй. Тэгтэл яг өмнөхөн нь явж байх шиг санагдав, Варя, яг даа, галбир, үс, алхаа гишгээ нь... Зүрх нь булгилан, алхалж өмнө нь гарлаа. Үгүй ээ, Варя биш байна!

Саша Казанийн буудал дээр ирж тасалбараа тэмдэглүүлэв. Одоо цахилгаан явуулах хэрэгтэй. Бөөн бэхний толбо болсон ширээ, бараг ширгэчихсэн бэх, ширээнээс утсаар аргамжсан, бичихээсээ ураг нь их сурагч үзэг, нэг ч сул сандал алга, босоогоороо л бичихээс.

хэн нэгэн түүний мөрөнд зөөлхөн хүрэв.

Эргээд харлаа.

Гайхамшиг тохиосонгүй.

Алчуурынхаа хоёр үзүүрийг энгэр дээгүүрээ зөрүүлээд зангидчихсан цыган бүсгүй түүний хажууд зогсож байв.

-Алив, шонхор оо, мэргэлүүл, хамаг үнэнийг чинь хэлж өгье.

-Баярлалаа, хэрэггүй.

Тэрээр ширээ рүү тонгойж, цахилгаанаа гүйцээж бичив: “Уфа Төв шуудан өөрөө хүлээн авагч Глеб Дубининд Хорин таванд гарлаа дөчдүгээр галт тэрэг долдугаар вагон Угтаарай Саша”.

1988-1990

Переделкино

ГУТГААР БОТЬ

ҮНС ЧАНДРУУ

Залуурчин, далайчин аль нь ч эрсджээ!

Заяа битүүлэг гагц дууч намайг л

Задгай шуурга эрэг дээр шиджээ.

Тийн би вээр, байц хясааны ёроолд,

Ээвэр нарнаа өмсгөл юүгээн сэврээнхэн

Эрээвэр сүлд дуугаа аяланхан суунам.

А. Пушкин

Нэгдүгээр хэсэг

1

– За, ялдам минь, чи азтай байна шүү! Анх удаа шуудан дээр очсон чинь чамаас цахилгаан ирчихэж! Би шууд л галт тэрэгний буудал руу харайлгачихлаа.

Глеб цагаан шүдээ яралзуулан инээж, Сашаг байн байн харна.

– Би гэрийнхээ эзэн авгайтай ганц хүн гээд тохирчихсон болохоор бас нэг хүн аваачих эвгүй байна. Чамд тусдаа байр л хайцгаая.

Тээш хадгалах газар чемоданыг авсан боловч үүргэвчийг нь “Түгжээгүй юм авдаггүй” гээд халгаахгүй маягтай. Саша “За, дарга аа, гайгүй шүү дээ, өнөөдөр авчихна” гээд хадгалагчид нэг рубль шургуулсанд үүргэвчийг нь чемоданых нь хажууд тавиад хоёр тээшний баримт өглөө.

– Явган явцгаая, аян хамтад нь хотоо үзүүлнэ биз гэж Саша санал гаргав.

Хүнсний дэлгүүр, аж үйлдвэрийн бараа, бичгийн хэрэгсэл, талхны мухлаг, эмийн сан... Яг Калинин шиг, ер нь хаана л бол ийм байдаг даа. Гундуухан байна. Нэг, хоёр давхар хуучин модон байшингууд. Хааяа байх тоосгон байшин дээр байгууллагын нэрийг оросоор, бас орос үсгээр башкир хэлээр бичсэн хаяг хадаатай байх аж. Гагцхүү ийм хаяг л энэ хот чинь Бүгд найрамдах автономит Башкир улсын нийслэл гэдгийг хэлж өгч байна. Тиймгүй сэн бол ердөө л хөдөөний хот, чулуу дэвссэн гудамж, хаа нэгтээ явган хүний банзан зам, зарим газраа явган зам ерөөсөө алга. Нуль тоос шороо.

– За, манай Уфа хот ямар байна?

– Орос хотуудын гуниг л байна...

тэрээр Глебэд тэгж хариулсан боловч дотроо энэ гуниг өөрийнх нь ч байж магадгүй... Дахиад л, хэддэх ч удаагаа юм бэ дээ, бас л шинээр эхлэх болж байна гэж боджээ.

—Аж төрж болно, башкирууд чинь номхон дөлгөөн, зочломтгой улс. Харин гомдох нь амархан. Чи тэдний дэргэд нэг их пээдийж болохгүй шүү, ялдам минь.

— Тэр л дутаж гэнэ дээ!

— Саяхан бид нар хэдүүлээ нийлцгээсэн юм. Тэгтэл Ленинградын нэг залуухан сэхээтэн өөр шигээ залуухан башкирт “Өө, өвгөөн, би чамтай санал нэг байна” гэх маягийн юм хэлчихгүй юү. “Өвгөн” гэдэг үгийг Ленинградын сэхээтнүүдийн хэлдэг маягаар хэлсэн юм. Тэгсэн чинь нөгөө башкир маань “Би өвгөн байхдаа яахав дээ?!” гээд цаадахынхаа хоншоор дундуур татаад авах нь тэр! “Өвгөн” гэхээр нь гомдчихсон хэрэг. Хүүхэн шуухан байсан бол ч бас яахав, тэдний нүүрэн дээр доромжиллоо гэх санж. Гэтэл дандаа харчуул, бүсгүй хүн огт байгаагүй.

Глеб “Айраг” гэсэн хаягтай байшинг зааж,

— Айраг зардгийг харж байна уу? Гүүний сүү, башкирууд тэрнээсээ архи гэж манай бараашигархуу юм нэрнэ, тэр ч байтугай спирт нэрнэ гээч. Уухыг үзүүлнэ, нөгөө коран судар энэ тэрээ тооно гэсэн юм байхгүй. “Мөнгөө байна аа — Уфа наргина аа, мөнгөө байхгүй ээ — Чишма сууна аа” гэв.

— Чишма гэж юу юм?

— Уфагаас холгүй байдаг нэг өртөө, замдаа анзаараагүй юү?

— Анзаараагүй.

— Уух дуртай, зууш даруулганд бүр ч их дуртай. Эдний мах гэвэл голдуу адуу, хонины мах. Бешбармак нь дажгүй, хоолой давахтайгаа.

Тэр хоёр хотын төвөөр, Егор Сазановын гудамжаар явж байв. Тэр нь хааны Плеве гэдэг сайдыг алсан, алуурчин, эсер. Уфа хотын хүн байсан юмуу, хаашаа юм? Аюулаас хамгаалахын дүрэмт хувцастай хүмүүс тааралдах нь элбэгшлээ. Гялалзтал тосолсон савхин гуталтай, хальфийтай өмдтэй, дөрвөлжин хөгжил хөдөлгөөнгүй царайтай.

— Үгүй, эд нар чинь энд яасан ч олуулаа юм бэ дээ гэж Саша өгүүлэхэд, Глеб нэг байшин руу зааж,

— Харж байна уу? ДЯАК-ын газар гэв.

Тэр нь бүдүүн төмөр саваагаар цонхыг нь торолсон, хоёр давхар урт тоосгон байшин бөгөөд дөрвөн орц нь бололтой, шилгүй хоёр хавтастай нүсэр хаалга бүхий битүү пин явган замын гол руу түрж орж иржээ.

— Глеб, Калининд паспортын дэглэм тогтоож байгааг чи мэдэж байсан уу?

– Мэдэж байсан.

– Надад хэлэхгүй яасан юм бэ?

– Хэлээгүй гэж юу гэсэн үг вэ? Би өөрийнхөө үгийг яг санаж байна: “Өнөөдөр бол Калинин тусгай дэглэмгүй байна, маргааш тусгай дэглэмтэй болно” гэж хэлсэн, тэр юу юм бэ?

– Хнн, битүү дохио юмуу...

– Тийм битүү дохиог хүүхэд ч ойлгоно. Би зүгээр ч үгүй чамд тэндээс явах санал тавьсан юм чинь.

– Битүү дохиог чинь би сэргийлэхэд очсон хойноо л ойлгосон.

– Чам шиг байдалд байгаа хүн арай түргэн сэтгэж байх хэрэгтэй.

– Харин ч сайн боллоо, юу гэвэл, бичиг баримт маань өвөрт байна, ажлаасаа халагдчихсан, байрныхаа бүртгэлээс хасуулчихсан. За тэр ч яахав, нөгөө оромдох ажлаа эхэлсэн үү?

– Хөөе ялдам аа! Чи яаж ингэж ярьж чадаж байна аа? “Оромдох ажил” гэнэ! Юу гэсэн үг вэ энэ чинь? Яг Семён Григорьевич Зиновьев өөрөө удирдаж байгаа бригад байна.

– Тэр чинь нөгөө Зиновьевийн хамаатан биш биз дээ?

– Тэр ч байтугай ижил овогтон ч биш. Марийнскийн театрын гоцлол бүжигчин байсан хүн, “Орчин үеийн нийтийн бүжиг” гэдэг номын зохиогч, би чамд өгнө, уншаад Сократ, Аристотель энэ тэр бүжгийн тухай юу гэж хэлж байсныг мэдэж аваарай. Семён бол мундаг хүн, томоохон зүтгэлтэн, хотын яг төвийн Хөдөлмөрийн ордыг түрээслээд авчихсан, үйлдвэр, заводтай гэрээ хэлцэл байгуулна. Хүн болгоноос гучин рубль татна, фокстрот, румба, танго, вальс-бостон заана гэснээ Глеб алхаагаа сааж, Сашагийн костюм, шаахай энэ тэр рүү харснаа,

– Чамд өөр костюм байхгүй юү? гэж асуув.

– Энэ юу нь муу байна?

– Маяг нь хоцрогдсон байна. Бас шаахай чинь... Шаахай бол хамгийн гол юм шүү дээ, ялдам минь! Аль чигт хөлөө хөдөлгөхийг харуулж заана, нөгөө шавь нар чинь юу руу харах вэ? Чиний гоё халимагийг уу, сэртэндсэн нүдийг чинь үү? Үгүй шүү, ялдам минь, хөлийг чинь л харна. Тэгээд майжийчихсан юм уу, балиар шаахай харах юм бол тэд чинь чиний зааж байгаа бүжигнээс нэг их баярлаж хөөрөхгүй гэж мэдээрэй, тийм биз дээ. Гоо зүйд харшлана! Чамд зангиа бий юү?

– Энэ насандаа зүүж үзсэнгүй.

– Зүүх л болно доо. Бас шаахай бол бүр өнөөдөр авах хэрэгтэй. Харыг. Хар шаахай ямар ч костюманд дүйнэ. Тоглоом шоглоом болгохгүй шүү, энэ ажил чинь зүгээр нэг бүжиг

мужигхэн биш. Энэ чинь үзэл суртал, мэдэж ав, ялдам минь.

– Бүр тэрэндээ хүрчих үү?

– Гучин хүнтэй бүлэг цугларч байна, үүнийг х э н ч сонирхохгүй байх уу, чи юу гэж бодож байна? Тэгээд ч тэр бүлэг нь ганцхан биш. Уфа тэр чигээрээ, орос башкиргүй өрнөд европын бүжиг хийцгээхийг хүсч байна. Тийм учраас үүнийг харж байх үүрэгтэй хүмүүс нь ажиглаж хянаж байх ёстой. За тэр ч яахав, манай албан газрыг очиж харцгаая.

Тэр хоёр Сазановын гудамжнаас нэг хөндлөн гудам руу эргэв. “Аялалын дагшаа тоглолтын товчоо” гэсэн хаягтай багашаархан байшингийн хавьд хүмүүс шавааралдан байх аж. Глеб,

– Намайг энд хүлээж бай гэчихээд дотогшоо орж алга болов.

Саша жаахан зайдуу очиж зогсов. Цугларагсдын дотор олон хүн бие биенээ мэддэг бололтой, нэр нэрээрээ дуудалцан, нэг бүлгээс нөгөө рүү очиж тэврэлдэх, үнсэлдэх зэргээр мэнд усаа мэдэлцэн, “Уулзалгүй хичнээн ч хаврыг үдэж вэ дээ!” хэмээн дуу алдацгаах ажээ. Энэ бүх байдалд хий дэврэн хөөрсөн, өнгөний зохиомол шинж илрээд байх шиг... Ийм хүмүүстэй яаж аж төрж, тэдний дэргэд яаж ажиллах хэрэг вэ? Танихгүй хүмүүс, эс мэдэх зан заншил. Сох больдог ч юмуу? Ямар ч хамаагүй нэг базад ажил хайдаг ч юм бил үү?

Глеб гарч ирээд, нэг хаягтай цаас үзүүлэв.

– Яг хотын төвд. Зочид буудал зөвхөн ардын, гавьяат энэ тэрд хүртээлтэй, бусад аливаа хүмүүн хөлсний байранд сууна. Чи энэ биржийг хараа биз дээ? Илбэчид, ховсчид, бүжигчид, шог дуучид... Курайгаа барьсан башкирууд. Курай гэж мэдэх үү?

– Үгүй чиш.

– Жимбүүр маягийн цуур, эгшиг нь их гунигтай... Баг бүрдүүлэх санаатай товчооны дэргэд шавааралдацгааж байгаа юм, гол нь олигтойхон зохион байгуулагч — амьд жүжигчин таарах явдал, тийм хүн түрүүлж очоод, аль нэгэн бөглүү зэлүүд газар ч сурталчилгаа таниулга хийгээд явчихна. Тоглолтын зарлал дээр үгүйдээн нэг алдартай хүний нэр байх нь маш чухал. Энд чинь элдвийн Качалов, Кторов, Церетели, Уланов гэхчилэнгүүд үй олноороо байгаа гэж мэд, ялдам минь! Яаж ч өөнтөглөхийн арга байхгүй. Бөөн булхай явж байгаа... гээд Глеб Саша руу хялайж, – Яагаад дуугаа хураачихав, ялдам аа? гэв.

– Бодож байна. Энэ ажил надад таарах уу, үгүй юү? Чи сая бөөн булхай гэж бас хэлж байна. Гэтэл би тэгж сураагүй хүн.

– Шудрага амьдрахыг хүсч байна уу?

– Яг тэгж байна.

– Шудрага л амьдрана шүү дээ, ажиллах цагаа ёсоор нь гүйцээнэ, тэгээд цалингаа авна. Бүх юм хууль номоороо явна, ялдам минь. Үүнийг чинь манай Мария Константиновна дарга хянаж байдаг юм, чи түүнтэй уулзана гайгүй, ажил хэрэгч авгай, гуталдаа зан гартал

шогшино, гэхдээ боловсон сэхээтэн. Өө тийм, байрныхаа хөлсийг чи өөрөө төлнө гэж мэдээрэй.

– Ойлгомжтой.

Булангийн байшин нэг талаараа Аксаковын, нөгөө талаараа Чернышевскийн гудамжны дагуу байралжээ. Жижигхэн байрны умгар өрөө. Гэхдээ Калининд байсан шиг даавуун хөшгөөр тусгааралсан өрөө эрхбиш биш. Юу шиг байхав. Юм юманд санаа зовсон, уймраа мартамхай эзэгтэй нүдний шилээ олж цөхөхдөө, эд нар л нэг тийш нь хийсэн байх гэж хүүхдүүдээ зүхэв. Арван нэг, хоёртой хүү, охин хоёр нь шилийг нь хайхаар гал тогоо руу орлоо. Хүүгээ ханиалгах бүрийд эх нь эгдүүцэн “Битгий мэнгэрлээд бай, шил хайгаатах!” гэж зандрана.

Тэгж тэгж нүдний шилээ олсны эцэст эзэгтэй,

– Томилолт хаа байна? гэж асуухад Глеб малилзан,

– Мария Константиновна их яарч байсан учраас ердөө хаяг л өгсөн, томилолтыг нэг дэх өдөр бичээд өгчихнө. Хаягийг чинь өөрийнхөө гараар бичсэн, та бичгийг нь танина шүү дээ гэв.

Эзэгтэй нөгөө цаасыг сэжигтэй гэгч нь эргүүлж тойруулан харав.

– Та эргэлзээд байна уу? Миний паспорт энэ байна гээд Саша халааснаасаа паспортоо гаргаж үзүүлэв.

– Надад таны паспортны хэрэг байхгүй, би таныг энд бүртгэж авахгүй.

Бүртгүүлэх хэрэггүй байх нь! Ёстой болж байна! Хамаг эргэлзээ шууд арилах нь тэр, Саша Калининд бүртгүүлэх гэж ямар доромжлол хүлээснээ нэхэн санаж л дээ. Энд тийм юм болохгүй нь. Айлчлан тоглогч жилд өчнөөн хотоор явдаг юм чинь, хот болгонд бүртгүүлж байлтай нь биш? Паспортын хуудас хүрэлцэхгүй шүү дээ. За яахав, бүжгээр л хичээллэхээс, ээ чөтгөр алгад гэж!

– Мария Константиновна бүх юмыг номоор нь бичээд өгнө гэж Глеб амлав.

– Харин ёстой яахгүй шүү... гэснээ эзэгтэй хүүхдүүдээ хажуугийн өрөө рүү түлхэн оруулж хаалгаа хаагаад, – Шөнө хүүхэн авчрахгүй байхыг л танаас гуйя гэв.

– Та юу хэлнэв? Яаж тэгж болох вэ, тийм биз дээ?

– Яаж болгоно гээч хэмээн эзэгтэй толгой сэгсэрч, – Танаас өмнө энд чинь Цветков гэдэг жүжигчин сууж байлаа. Архичин нь багадсан юм шиг бүр авгай хүүхэн авчрана. Харахад тохьтой хүн, гэтэл ямар муухай хэрэг тарина гээч. Би чинь хүүхэд шуухадтай хүн шүү дээ.

– Би таны санааг зовоохгүй байхыг хичээнэ ээ гэж Саша өгүүлэв.

1937 оны 8 дугаар сарын 23-нд Кремлийн ордны Георгийн одонт танхимд Москвагаас Америк хүртэл Хойт туйл дээгүүр буултгүй нислэг хийсэн нисгэгч Громов, Юмашев, штурман Данилин нарт зориулсан хүлээн авалт болов.

Тайз руу чагтлан тавьсан олон ширээнд нам засгийн томоохон зүтгэлтнүүд, дээд тушаалын цэргийн эрхтнүүд, онгоцны тэргүүлэх зохион бүтээгчид, алдарт нисгэгчид, шинжлэх ухаан, соёлын нэрт зүтгэлтнүүд сууцгаасан байлаа. Зочин болгоны ач холбогдол, тэдгээрийг нөхөр Сталин юу гэж үздэг болон хүлээн авалт дээр биеэ авч явах тухайд төдийгүй бусад бүх утгаар найдвартай эсэх талаар сайтар мэдээлэлтэй жич хүмүүс зочноор хэнийг урих асуудлыг хариуцна. Чухам эдгээр жич хүмүүс л хэнийг гэргийтэй, хэнийг гэргийгүй урих, хэн аль ширээнд, аль суудалд суухыг шийднэ. Нөхөр Сталин ойролцоох ширээн дээрээ танил хүмүүсийн царайг харж байвал тайван байх шүү дээ. Нөхөр Сталин “Энэ чинь хэн бэ?” гэж асуугаад байх дургүй. Энэ чинь хэн бэ гэдгийг нөхөр Сталин өөрөө мэднэ!

Ширээ дүүрэн дарс, амтат зууш тавилсан байвч гар хүрч байгаа хүн алга: тайзтай зэрэгцээ, бусад ширээнд чагтлуулан арай зайтайхан байрлуулсан, гол ширээн дээр бас л дарс, амтат зууш тавилсан боловч олон лонх, галуун хүзүүт, шилбэт жүнз, жимстэй хөлт тавагнуудын цаагуур эзгүй сандлууд эгнэн бүхий нь нам засгийн удирдагчид хараахан орж ирээгүй байгаа нь тэр. Тэднийг орж ирэх сэтгэл догдлом мөчийг хүлээзнэн зочид өөр хоорондоо биеэ барьсхийн аяархан хөөрөлдөнө. Цаг руу хэн ч эс харна. Цаг руу харна гэдэг бол тэсч ядаж байгаагаа харуулна, энэ бол эвгүй, энэ бол нөхөр Сталинд үнэнч бус байгааг харуулна.

Мундаг эгшин тохиож буйг хоол зөөгчид хүртэл илтгэнэ: цагаан элгэвчтэй, хар костюмтай, шуун дээгүүрээ цагаан алчуур тохсон, догшин хэрнээ юуг ч эс илтгэх царайтай хүдэр залуус суугаа зочдын дээгүүр дүүхийлцэн ширээний араар хөшсөн мэт зогсоцгооно. Олон хаалганы дэргэд бас хоёр хоёр зөөгч зогсож байна. Зөөгчдийг ДЯАК-ын орон тооны ажилтнууд гэдгийг бүгд мэднэ, тэд ордны бүх хонгил гудаа, бүх давхар, бүх шатан дээр зогсож байгаа хамгаалалтынхан, ширээ болгоны ард чамгүй тоотой байгаа ДЯАК-ын орон тооны бус ажилтнуудад нэмэгдэл хүч болж байгаа юм.

Яг долоон цагт хажуугийн хаалганууд онгойж, Сталин Улстөрийн товчооны гишүүдээ дагуулан танхимд орж ирлээ. Бүх хүн сандлаа зайчлан босцгоож, нижигнэсэн алга ташилт танхимаар нэг цууриатлаа. Удирдагчдыг ширээ рүүгээ очин очтол уухай, алга ташилт үргэлжлэн цууриатаж, тэг тэгсээр дарга нар сая өөрсдийн суудалд очиж зочид руугаа харж, өөрсдөө хариу алга ташицгаав. Танхим жолоодогч нар руу, жолоодогч нар танхим руу алга ташицгааж байна. Тэгснээ Улстөрийн товчооны гишүүд Сталин руу эргэж, түүн рүү алга ташицгаав. Танхим ч бас нөхөр Сталинд хүрэхийг оролдох мэт түүний зогсож байгаа зүг гар сунган алга ташицгааж байна. Гагцхүү ширээний дэргэдүүр урьдын адил хөшсөн мэт зогсож буй үйлчлэгч нар л алга эс ташина. Харин сууж байгсад боссон болохоор тэднээс олон хүн хоол зөөгчдөөс биерхүү, байрархуу буйн учир мань зөөгчид дүүхийлцэж харагдах нь мэдэгдэхгүй болжээ.

Сталин тохойгоо бараг нугалахгүй, гараа ширээний дээгүүр дөнгөж цухуйлган, хоёр алгаа

хооронд нь хүргэх төдийхөн таших зуур ойр зуур зогсогсдыг буумал зовхиныхоо доороос хүйтэн харцаар зугуухан харж байв. Тэднийгээ нэгбүрчлэн харж таньж аваад, танхимын гүн рүү хараагаа шилжүүлсэн боловч өргөсөн олон гар сэрийлцээд, тэрээр хэнийг ч ялган таньж эс чадав. Тэгмэгц мань хүн алга ташихаа больж сандалдаа суулаа. түүнийг даган, хажууд нь зогсож асан Молотов, Ворошилов хоёр эхлээд, дараа нь Улстөрийн товчооны бусад гишүүн суудлаа эзэлцгээв. Харин зочид алга ташин зогссоор байлаа. Тэгэхүй дор Сталин зочдоо суухыг урьж, гараа хоёр удаа өргөх төдий дохиод буулгав. Гэтэл цаадуул нь хөөрсөн сэтгэлээ дарж чадах царай алга. Тэд нар ийшээ архи, коньяк, оргилуун дарс, “Мукузани” уух гэж ирээгүй, түрс, яргай загас, илэгний нухаш, мөөгний зуган, “киев маягийн” шабмаг идэх гэж ирээгүй. Тэд ийшээ нөхөр Сталиныг харах гэж, түүнд хайртай, үнэнч гэдгээ илэрхийлэх гэж ирсэн билээ.

Сталин Молотовт нэг юм хэлэхэд мань хүн босч, “Нөхөд өө, одоо бол оо! Нөхөр Сталин та бүхний сэтгэлийг ойлгож байна, үнэлж байна, гэхдээ бид чинь энд тодорхой ажлаар цугалсан шүү дээ, тэр ажилдаа орцгооё. Уриа уухайгаа больж, сууцгааж үз!” гэж хэлэх мэт хоёр алгаа дээш нь харуулан гараа өргөв.

Тэргүүлэгчдийн байранд ойрхон зогсогсод эхлээд алга ташихаа больцгоов. Үйлчлэгчид тэдний архи хүссэнд нь архи, дарс хүссэнд нь дарс хундагалан араар нь миегнэлдэж эхлэв.

Харин бусад зочид нь нөхөр Сталин өөрсдийг нь бас хараасай, царайд нь, харцанд нь хязгааргүй хайр энхрийлэл гэрэлтэн буйг мэдэж аваасай хэмээн алга ташсан чигээрээ зогссоор байв. Молотов гараа бүр дээш нь өргөж, Улстөрийн товчооны гишүүд танхимын голд байгаа зочдыг ч бас харж байна, бүгд ойлгож байна, үнэлж байна, гэхдээ суухыг хүсч байна гэж тэдэнд ойлгуулан дохив. Танхимын голынхон ингэснийх нь хариуд дахин хэдэн хором алга ташаад суудалдаа сууцгаалаа. Үйлчлэгчид тэдэнд архи, дарс аягалан бас хөлхөж эхлэв.

Хамгийн захын ширээнийхэн л зогссон чигээрээ алга ташсаар байлаа. Одоо өмнөх улс нь бүгд сууцгаасан болохоор өөрсдийг нь ч бас Сталин харна гэж найдацгааж байгаа нь тэр. Молотов хажуугийн хаалганы тэнд зогсож буй хэн нэгэн рүү хармагц, цаадах нь бас нэг хүн рүү дохихуйд, захын ширээний үйлчлэгчид тэр даруй хөдөлцгөөж, намбатай боловч шаргуу гэгч нь “Нөхөд өө, алив сууцгааж болгоо... Алив нөхөр та! Таныг суу гэж байна шүү дээ! Алив, алив, нөхдөө, бушуулаарай...” хэмээн шаардацгаав. Тэр ч бүү хэл сандлыг нь биед нь шүргүүлэн хөдөлгөж эхэлсэнд эрхэм зочид байрандаа бушуухан сууцгаав. Тэгээд үйлчлэгчид тэдний хундагыг ч бусад ширээний нэгэн адил архи, дарсаар дүүргэлээ. Молотов бослоо, тэгмэгц үйлчлэгч нар ширээний хажуугаар хөших мэт номхон зогсоцгоов.

Молотов амьдралын бүх салбарт зөвлөлтийн ард түмний олсон хэзээ ч байгаагүй ололт амжилтыг дурдав. Энэ амжилт хөгжлөөрөө Зөвлөлт Холбоот Улс бүх дэлхийг хошуучилж яваа манай хүчирхэг нисэх хүчний жишээнээс онцгой тод харагдаж байна. ЗСБНХУ нисэх хүчний хувьд аугаа их гүрэн болсон нь нөхөр Сталины суут удирдлагын ач гавьяа мөн. Нөхөр Сталин нисэхийн аж үйлдвэрийг хөгжүүлэхэд биечлэн асар их анхаарал хандуулж, манай орны яруу алдарт шонхоруудыг — нисгэгчдийг эцгийн ёсоор халамжлан хүмүүжүүлж байгаа билээ.

Танхимд дахин уриа хадаж, сандал түжигнэлдэн зочид босч, нөхөр Сталин руу гараа сунган алга ташиж эхэллээ. Сталины нэрийг нэгэнт нэрлэсэн болохоор энэ уухай, энэ нижигнэсэн алга ташилтыг чухамхүү түүнд биечлэн зориулж байгаа болой.

Сталин босч гараа өргөсөнд, танхимд нам гүм болов.

– Цааш нь ярь л даа, нөхөр Молотов гэж хэлээд Сталин суучихав.

Хэн хүнгүй инээлдэж, инээмсэглэж, Сталины наргианыг хөхиүлэн дахин алга ташицгаав.

Молотов үргэлжлүүлэх гэтэл нисгэгчдийн сууж байсан эхний ширээний араас Чкалов босч, өргөн мөрөө ханхалзуулан, цээж дүүрэн амьсгалснаа,

– Манай эрхэм хүндэт Сталинд — ура, ура, ура! гэж хашгарах нь тэр.

Танхим түүнийг түрэн авч гурвантаа ура хашгарлаа.

Сталин дотроо жуумалзав. Засгийн газрын тэргүүний үгийг уул нь таслах ёсгүй. Гэвч энэ бол түүний хайртай Чкалов, оросын ид хав, цог заль, золбоо хийморийн биелэл болсон хүн, Чкалов бол түүний эриний, түүний цаг үеийн аугаа их нисгэгч. Одоо яая гэхэв, энэ эрэлхэг зоригтон ёс жаяг төдийлэн мэдэхгүй байгааг Молотов хүлцэх ёстой болж байна.

Молотов туршлагатай дарга болохоор танхимыг тайвшруулаад яриагаа үргэлжлүүлэв.

– Манай эрэлхэг зоригт нисгэгчид Громов, Юмашев, Данилин нарын хүн төрөлхтний түүхэнд байгаагүй амжилт манай нисэх хүчний аугаа их хүч чадлыг гэрчилж байна. Эд нар Хойт туйлын дээгүүр Америк руу (Молотов нэг цаас харав), Калифорнийн Сан-Жасинто хот хүртэл ниссэнээрээ буултгүй нислэгийн алсын зайн дэлхийн дээд амжилт тогтоолоо.

Сталин дахиад дотроо жуумалзав. Молотов үгнийх нь дундуур орсон Чкаловоос хариугаа авчихлаа. түүний нислэгийн талаар тоож дурссангүй. Уул нь анхлан зам гаргагч нь Чкалов шүү дээ: тэр л анх Хойт туйл дээгүүр нисч Америк хүрсэн. Молотов нэрээ хичээмтгий, бас гомдомхой нөхөр. Мулгуудуу хүмүүс дандаа гомдомхой байх юм даа.

Молотов хэлэх үгээ Громов, Юмашев, Данилин нарын төлөө хундага өргөж төгсгөв.

Дахиад л алга нижигнэж, “Зөвлөлтийн нисгэгчдэд – ура!” гэж хашгаралдав. Гэхдээ нэг ч хүн болсонгүй. Гагцхүү нөхөр Сталины төлөө л босдог ёстой билээ. Тэргүүлэгчдийн ширээ рүү уригдсан гурван нисгэгчтэй хундага тулгахаар нөхөр Сталиныг өөрөө босоход зочид бас босцгоов. Гэхдээ Сталиныг суунгуут бас дор дороо бушуухан сууцгааж, Молотовын урт үгийг сонсох зуур гэдэс хонхолзсоныг ч хэлэх үү, түүнээс гадна энэ оройн элбэг дэлбэг хоолыг зөгнөн, өнөөдөр гэр орондоо ч идэж уухаа нэг их өмнөө бариагүй байлгүй, зууш руу шамдан орцгоов.

Уран сайхны хөтөлбөрийн салхийг урьдын адил Александровын удирдсан улаан армийн дуу, бүжгийн ансамбль хагалж, урьдын адил мөнхүү Александровын зохиосон Сталины тухай магтуугаар ая өргөв. Магтууг хоол ундаа орхин байж сүсэглэн сонсоцгоолоо. Тэгээд

ансамблийг дараачийнхаа үзүүлбэрийг эхлэнгүүт эрчүүд архи руу, эмэгтэйчүүд дарс руу, аль аль нь зууш руугаа хомхойрон орцгоох нь тэр.

Ансамблийн дараа Козловский, Максакова, Михайлов энэ тэр, дараа нь Образцов хүүхэлдэйтэйгээ ээлж дараалан гарч ирцгээв... Жолоодогч нар тайз руу эргэн тэднийг харж, зочид нь энэ бүхнийг зуунтаа харж, зуунтаа сонссон болохоор идэж уухаа хичээцгээж байв.

Жүжигчдийн тоглолтын завсраар хундага өргөцгөөнө. Мэдээж, бүгд Сталины төлөө. Нисэх хүчний тэргүүлэх зохион бүтээгч: “Нөхөр Сталин нисэх хүчинд ажилладаг хүмүүсийг сайн мэддэг, техникийн нарийн асуудлуудын шийдлийг хэлж өгдөг, зохион бүтээгч бид нарт алс ирээдүй рүү харж байхыг зааж сургадаг” гэж авлаа.

Дахиад л нөхөр Сталины төлөө ууж, идэцгээнэ. Сталин ч бас ууж байна, гэхдээ заншсан ёсоор бараг юм идэхгүй. тэрээр ийм хүлээн авалтад дуртай, ач холбогдлыг нь ойлгоно, хаад бүжигт наадам зохиож байсан нь талаар хэрэг үү, Петр хаан өөрийн бүжигт наадамтай байсан нь санаандгүй л хэрэг байв гэж дээ. Энэ бүхэн эзэнтний захиргааг баяр ёслолын гэрэл гэгээтэй болгохын хамт хүрээлэгчдэд нь түүний найртай байгааг мэдрэх боломж, түүний ололт амжилт, түүний ялалтыг тэмдэглэх боломж олгоно.

Ард түмэн ялалтад дуртай, ялагдалд дургүй, гагцхүү ялалтаа санаж байдаг, ялагдлаа санах дургүй. Донын Дмитрий, Невийн Александр, Ермак энэ тэрийн ялалтыг санана, Казань, Астраханийг эзлэн авсныг санана, Полтавын тулалдааны ялалт, Наполеоныг бут цохсон ялалтыг санана. Харин татарын дарлалыг, Девлет-Гирей хан Москваг галдан шатаасныг санах дургүй, Севастопольд болон Порт-Артурт ялагдсаныг санахыг эс хүснэ. Ард түмэн зөвхөн ялалтыг түүхэн ой санамждаа үлдээгээд, саяных мэт бүх ялагдлыг хөсөр таягдан хаяна. Орос хүн онгирч хөөрцөглөх дуртай, энэ бол цусанд нь байгаа зан, олон зууны хоцрогдол, гуйланчлал, боолчлогдлынх нь нөхвөр тэр. тэрээр энэ тухайд цөллөгт байхдаа сайн мэдэж авсан, хөдөөгийн тариачдаас олж харсан, бас Бакугийн ажилчдаас ч анзаарсан. Омголон, дүрэлзүүр гүрж хүн дарс уучихаад бусад гүржтэйгээ гүрж дуу дуулж, бүжиг хийж хөгжин баясана. Харин номхон дөлгөөн нэг муу орос уучихаараа зодоо хийнэ, хүч чадлаа нотлоно. Энэ онгиороо зан бол орос үндэсний зан чанарын чухал бүрэлдэхүүн хэсэг, үүнээсээ болж орос хүн улангассан хэрэг тарина. Чухам ийм учраас ард түмэн баатартаа тэгтлээ хайртай, чухам ийм учраас нисгэгчид ийм их нэр хүндтэй байгаа, эд нар ард түмнийхээ хүч чадал, өөрсдийнх нь хөвүүдийн ид хав, эрэлхэг зоригийг бүх дэлхийд харуулж байгаа. Тэгээд ард түмэн ТЭР л тэднийг ингэж хүмүүжүүлсэн хэмээн түүнд талархаж байгаа. Тийм учраас мань ХҮН хоцрогдсон, түгжигдмэл, боловсролгүй ард түмнийг баатар-ард түмэн болгож хувиргаснаараа бахархаж болно. тэрээр ард түмэн түүний удирдлагаар хүрсэн ололтын хэмжээгээр аугаа их болж түүхэнд үлдэнэ. Харин төвлөрсөн хүчирхэг гүрнийг цогцлон байгуулахад үрсэн гарлага бол мартагдана. Түүхийн хог дээр түүний хаясан арчаагүй өчүүхэн амьтдыг, өөрсдийгөө “Лениний ахмад гвардынхан” гэж нэрийддэг муусайнуудыг хэн нэхэн дурсах юм бэ? Амь өрсөн аюулын сэжиг авцгаачихаж! Бүүр “үнэнч анд” Клим Ворошилов хүртэл өмдөндөө авчихаад, өөр рүү нь: “Коба, намайг барих гээд ирцгээвэл би яах вэ?” гэж утасдсан. мань хүн тэгэхэд хэсэг дуугаралгүй, түүнийг жаал шаналааж байгаад дараа нь: “Чи тэд нарт хаалгаа онгойлгож өгөхгүй л байхгүй юү” гэж хэлсэн. Тэгмэгц сэтгэл нь онгойсон, улаа бутарсан мангуу толгой одоо хажууд суучихсан ууж байна, малилзаж байна, арга ч үгүй

дээ: цэргийн нисгэгчид түүний боловсон хүчин юм чинь. Зугаацаж л байг.

Сталин Молотов, Ворошилов хоёртой зэрэгцэн, ширээний ард дарс шимэн, хаа нэг зуушнаас амхран, жүжигчид тоглох үед тайз руу эргэн, хундага өргөгч бэлэн цэцэн үгтнүүдийг эс сонсон суух зуур ийнхүү бодолхийлж байв. тэрээр хундагаа өргөн аль алинд нь алга таших мэт байснаа Молотовт хандан,

– Би үг хэлье гэв.

Молотов хутгаар хундагаа тогшилсон боловч тэр чимээг хэн ч сонссонгүй, харин үйлчлэгч нар нүд ирмэхийн зуур байр байрандаа хөшихүйд танхимд анир чимээгүй болж, бүх хүн тэргүүлэгчдийн зүг хараа хандуулав. Молотов,

– Нөхөр Сталин үг хэлнэ гэж зарлалаа.

Сталиныг босоход тэр даруй цөмөөрөө босцгоолоо. Дахиад л уухай, дахиад л алга ташилт.

Сталин гараа өргөсөнд бүгд дорхноо нам гүм болцгоож, түүнийг гараа буулгамагц бүгд сууцгаав. Сталин,

– За нөхөд өө, хундагануудаа дүүргээрэй гэв.

Хөнгөн шингэн хөдөлцгөөж, хэн хүнгүй дарс хундагалах гэж яарцгаасан боловч нөхөр Сталиныг хүлээлгэж болохгүй юм чинь, эрж байх цаг алга, гарт таарсан юунаас ч хамаагүй аягалцгаав.

Дахиад нам гүм болов.

– Би энэ хундагыг Зөвлөлт Холбоот Улсын өнөөгийн болоод ирээдүйн баатрууд, манай эрэлхэг зоригт нисгэгчдийн төлөө өргөхийг хүсч байна хэмээн Сталин эхэлж, – Тэдэнд, өнөөгийнхэнд, ялангуяа Зөвлөлтийн ирээдүйн баатруудад би, эрэлхэг зориг бол Зөвлөлт Холбоот Улсын баатруудын салшгүй шинж чанар мөн гэдгийг хэлэх байна. Нисгэгч гэдэг бол чивчирсэн хүсэл зориг, тийм араншин, азаа турших чадвар юм. Гэхдээ эрэлхэг зориг бол баатарлаг явдлын зөвхөн ганцхан тал нь. Үүнээс дутуугүй өөр нэг чухал тал нь чадвар. Эр зоригоор хот тосгодыг эзлэнэ гэлцдэг. Гэхдээ энэ бол эрэлхэг зориг, азаа турших чадвар маш нарийн мэдлэгтэй хавсарсан цагт л бүтэх хэрэг. Чухам ийм байгаарай гэж л би манай эрэлхэг зоригт нисгэгчдийг, манай ард түмний яруу алдарт охид хөвүүдийг уриалж байна. Би манай Зөвлөлт Холбоот Улсын өнөөгийн болоод ирээдүйн баатруудад баяр хүргэж байна. Би энэ хундагыг өнөөгийн болоод ирээдүйн баатруудын төлөө өргөж байна. Жижиг болоод том нисгэгчдийн төлөө өргөж байна, хэн нь том, хэн нь жижгийг мэдэхгүй, энэ бол үйл ажлаар нотлогдох болно. Бид нөхөр Громов, Юмашев, Данилин нарын төлөө нэгэнт ууцгаасан. Гэхдээ эдний баатарлаг нислэг бусад нисгэгчдийн гавьяагаар бэлтгэгдсэнийг бид мартаж өсгүй. Тэд бол Хойт туйлын дээгүүр Москва АНУ-ын Ванкуверийн хооронд анхны буултгүй нислэг үйлдсэн, манай үеийн гарамгай нисгэгчид, Зөвлөлт Холбоот Улсын баатрууд — Чкалов, Байдуков, Беляков нар гээд Сталин нисгэгчдийн сууж байгаа ширээ рүү хуруугаараа зааж, – Чухамхүү тэд нар, Чкалов, Байдуков, Беляков нар Хойт туйлын дээгүүр Америк орох

замыг нээсэн. Нөхөд өө, манай яруу алдарт нисгэгчид, Зөвлөлт Холбоот Улсын өнөөгийн болоод ирээдүйн баатруудын төлөө ууцгаая гэв.

Сталин хундагтайгаа уулаа. Бусад нь ч бүгдээрээ ууцгааж, жүнзээ ширээн дээр тавиад алга ташицгаалаа. Тэдэнтэй Сталин өөрөө ярилаа шүү дээ. Бүгдээрээ “Нөхөр Сталин мандтугай... Нөхөр Сталинд – ура!” хэмээн хашгаралдан алга ташицгаалаа. Нисгэгчид онцгой хичээнгүйлж, хэм нийлүүлэн алга ташицгааж, хоолой нийлүүлэн уухайлж байв. Тэдний ширээнээс Чкалов, Байдуков, Беляков гурав босч тэргүүлэгчдийн ширээ рүү зүглэв. Тэднийг дуудсан нь мэдээж. Тухайлсан урилгагүйгээр тэргүүлэгчдийн ширээг бусад ширээнээс заагалсан зайг нэвгэрч зориглох хэн ч байхгүй. Сталин нисгэгчдтэй гар барив, түрүүн Громов, Юмашев, Данилин энэ тэртэй гар барьсан, одоо бол гол бөгөөд хайртай нисгэгчийн ээлж. Гэтэл Чкалов, Байдуков, Беляков гурав тэргүүлэгчдийн ширээ рүү хундагатай ирцгээжээ. Чкалов ам нээн,

– Нөхөр Сталин, танд хандахыг зөвшөөрнө үү гэв.

– Тэг тэг.

– Тантай тулгаж таны төлөө уухыг зөвшөөрнө үү?

– За яахав, уусан ч болно.

Сталин жүнзэндээ дарс аягалж нисгэгч нартай тулгаж, цөмөөрөө ууцгаалаа.

Сталин жүнзээ ширээн дээр тавьснаа,

– Өөр ямар нэгэн хүсэлт байх уу? гэв.

– Нөхөр Сталин хэмээн Чкалов нүд рүү нь эгцлэн хараад, – Бүх нисэх бүрэлдэхүүний нэрийн өмнөөс... одоо Леонид Утесов ая барина... Бүх нисэх бүрэлдэхүүний нэрийн өмнөөс... Бид гуйж байна... Утесовт “Одессийн гяндангаас”-ыг дуулах зөвшөөрөл болгооно уу гэв.

– Юун дуу билээ? гэж Сталин энэ дууг мэддэг хэрнээ асуув. Васька хүү нь гэртээ энэ дууг аялдаг, мань ХҮН хүүгээ ялтны дуу дууллаа гэж дургүй байдаг билээ.

– Гайхамшигтай дуу, нөхөр Сталин. Үг нь шоронгийнх, ялтных байж мэднэ, нөхөр Сталин, гэхдээ ая нь дайчин шүү, жагсаалын ая даа, нөхөр Сталин.

– За яахав, дуулаг л дээ, сонсоцгооё хэмээн Сталин болгоов.

Жүжигчид өөр өөрийнхөө гарах ээлжийг хүлээн холхилдож байгаа жүжигчний өрөөнд (нэгэнт тоглочихсон жүжигчид нь хажуугийн танхимд зориуд тэдэнд зассан ширээний ард тухалцгааж байгаа) дүрэмт цамцныхаа зах дээр гурван ханалжинтай цэргийн хүн орж ирээд Утесовыг дуудан,

– Юу дуулах гэж байна, нөхөр Утесов? гэж ширүүн асуув.

Утесов хөтөлбөрийн дагуу дуулах дуугаа нэрлэв.

– “Одессийн гяндангаас”-ыг дуулна шүү гэж цэргийн хүн тушаав.

– Үгүй, үгүй, тэр дууг чинь дуулахыг надад хориглосон хэмээн Утесов бүр айчихав.

– Хэн хориглоов?

– Нөхөр Млечин. Хөтөлбөрийн хорооны дарга.

– Таны тэр дарга надад хамаагүй. “Одессийн гяндангаас”-ыг дуулна шүү.

– Үгүй, нөхөр Млечин...

Цэргийн хүн түүн рүү нүдээ бүлтийлгэн,

– Иргэн Вайсбейн гуай, танд тов тодорхой хэлэв биш үү?! гэснээ, – Нөхөр Сталины шийдвэр шүү гэж шазуур зуун шивнэв.

Тийнхүү Утесов жаз хөгжимтэй хамсран “Одессийн гяндангаас”-ыг эхлээд дууллаа:

Одессийн гяндангаас хоёр ялтан оргожээ,

Хоёр ялтан оргож наранд гарсан юмсанжээ...

Абнярийн өргөөнд тэр хоёр буужээ,

Тэр хоёр амсхийхээр тэнд буужээ.

тэрээр нөхөр Сталины заавраар жигүүрлэн ад онгодтой дууллаа. Тийн дуулахдаа энэ мөчөөс хойш ямар ч хөтөлбөрийн хорооноос айх юм байхгүй, “Гяндангаас”-аа ч, “Мурка”-гаа ч, бусад хориотой дуугаа ч хойшид дуулж байх болно хэмээн ухамсарч байв.

Найрал хөгжимчид ч бас аатай наадаж. Цохивор хөгжимчин бөмбөр, цангаа ид шидээр амилуулан, бүрээчин, саксофончин уран тоглохын гайхамшгийг үзүүллээ.

Юу гээч болж байгааг ойлгох хүн алга. Нөхөр Сталиныг байж байхад, и й м хүлээн авалт дээр Утесов ялтны дуу дуулж зүрхлэнэ гэнэ ээ. Энэ чинь юу гэсэн үг вэ?! Үзэл суртлын хорлон сүйтгэх ажиллагаа юу?! Юун алга таших, бүгдээрээ зэрвэс хөдлөхөөс ч айцгаачихаж. Тэр ч бүү хэл, Чкалов, Байдуков, Беляков гурав хүртэл нөхөр Сталин юу гэж үзэхийг мэдэхгүй дуугаа хураачихаж. Яах учраа алдсан хөгжимчид бүрээ сэлтээ буулгаж, сох нам гүм бүхийд алмайрч гүйцэн царай нь хувхай цайсан Утесов дэмий л төгөлдөр хуурын ирмэгээс барин зогсох зуур, өдөөн хатгалга байсан юм биш биз, тэр цэргийн хүн өөрийг нь муухай чадсан хэрэг биш биз, тушаалаар дуулсан гэж батлана гэж юу байх вэ дээ, тэр цэргийн хүн нь ч хэн юм, нэрийг нь ч мэдэхгүй, гурван ханалжингаас нь өөр санах юм алга гэхчлэн айдаст автан

бодож байв.

Тэгтэл гэнэт аяархан алга таших сонсодсон чинь нөхөр Сталин өөрөө алга ташиж байх нь тэр. Танхим ч тэр дор нь түүнийг түрэн авч нижигнүүлэн алга ташлаа. Нөхөр Сталин алга ташиж байгаа бол энэ дуу өөрт нь таалагдсан гэсэн үг, энэ дууг өөрөө сайшааж байна гэсэн үг. Тэр нь ч зүйтэй! Наргивал наргисан шиг нарги! Зүйтэй! Ёстой мундаг! Дахиул! Дахиул! Ёстой мундаг!

Хар хөлс нь цутгасан Утесов арайхийн сэхээ орж, мэхийн ёсолж, найрал хөгжимчид рүү эргэн удирдаачийн сурамгай хөдөлгөөнөөр дохиход, цаадуул нь босч, танхимыг мэндчилэх мэт зэмсгээ тоншицгоож байв. Танхим ч алга нижигнүүлэн, “Дахиул! Дахиул!” гэж хашгачаад чимээ намдах царай алга. Сталин Утесов руу хараад, одоо яана гэхэв, ард түмэн хүсч байна, ард түмэн шаардаж байна, ард түмэнд үгүй гэж болохгүй... гэх маягтай гараа алдлан дал мөрөө хавчив.

Утесов дахин дууллаа.

Нөхөр минь, нөхөр минь, шарх минь өвдөөд байна,

Миний шарх буларч өвдөөд байна.

Нэг нь аниад, нөгөө нь идээлээд байна,

Гуравдах нь сүвээгээр задраад байна.

Нисгэгчид даган аялаж, дороо дэвслэн, зарим нь хутга, сэрээгээр таваг, жүнзийг хэм тааруулан тогшилж байна. Бусад ширээнийхэн ч бас даган аялаж, дороо дэвслэн байх агаад Утесовыг дуулж дуусахад бас л “Дахиул! Дахиул!” хэмээн хашгаралдацгаалаа. Бас нөхөр Сталин ч алга ташиж байна, Улстөрийн товчооны гишүүд ч алга ташиж байна, нөхөр Сталин дахиад л дал мөрөө хавчин, гараа алдлахуйд Утесов гуравдахиа дахин дууллаа.

Нөхөр минь, нөхөр минь, ээжид минь хэлээрэй,

Хүү чинь албандаа яваад амь эрдсэн гээрэй.

Нэг гартаа хурдан буутай, нөгөөдөө хурц илдтэй,

Амандаа хөгжүүн ая дуутай эрдсэн гээрэй.

Нисгэгчид юун даган дуулах, хоолой мэдэн бархиралдаж, ширээн дээр үсрэн гарч, архи дарс, идээ будааг асгаж цутган, дэвслэн бүжиглэцгээж гарах нь тэр. Тэр ч атугай, зохиолч Алексей Толстой, танхил эмийн царайтай, бүдүүн, буурьтай хүн шүү дээ, тэр хүртэл ширээн дээр гарчихсан, сав суулга бусниулан дэвхцэж байх аж. Гүн хэргэмтэй хүн гэж байгаа, мөн ч айхтар хөөрч дээ.

Энэ дуу бол мэдээж ялтны тухай дуу, гэхдээ нэг юм хэлээд байна аа. Үг нь их уяхан, эрүүгийн хэрэгтнүүд ийм үгэнд дуртай. “Шарх минь өвдөөд байна... Ээжид минь хэлээрэй...” Харин ая

нь бол тодхон хэмтэй, арзганатал гижигдээд өгнө. тэрээр эрүүгийн ялтнуудыг сайн санаж байгаа, тэдэнтэй шоронд ч, цөллөгт ч тааралдаж байсан. Мэдээж гэмт хэрэгтэнгүүд. Тэгэхээр одоо бол, тэд социалист өмчинд халдаж байгаа бол, тэднийг маш чанд мөрдөж, хатуу гэсгээн цээрлүүлж байх хэрэгтэй — социалист өмч бол халдашгүй дархан зүйл. Харин тэгэхэд, хаант засгийн үед бол, шудрага бус ёс, дарлал, гуйланчлалыг сөрөх эсэргүүцэл, гэмт хэрэг хоёрын ялгаа арилчихаад байсан. Бичиг үсэггүй, жирийн хүмүүс нийгмийн эрхэм дээд сонирхлын хэмжээнд тэр болгон хүрч сэтгэхгүй. Өөрийнхөө хувьд л шудрага ёсыг хүснэ, эд баялагийг өөрийнхөө түвшинд л дахин хуваарилахыг шаардана. тэрээр Бакуд, Баиловын шоронд байхдаа өөрийн “журмын нөхөд” болох улстөрийнхнөөс илүү эрүүгийн ялтнуудтай өөриймсөг харьцдаг байсан. “Журмын нөхөд” нь байнга маргалдана, онолдоно, сайн муудаа хүрнэ, ил далд явуулга, хэрүүл маргааныхаа учрыг олох гэнэ, хүн болгон бусдаасаа илүү ухаантай, илүү боловсролтой, илүү жудагтай гэж зүтгэнэ. Эрүүгийн хэрэгтнүүдийн хувьд энэ бүхэн тун тодорхой, тун энгийн байдаг билээ. Тэд хэн ч зөрчдөггүй, эгэл хууль, дүрэм, заншилтай. Үүний хамт цэгцтэй, сахилгатай. Толгойлогчдоо үг дуугүй захирагдана, байгууллагадаа чин үнэнчээр зүтгэнэ. Урван тэрсэлбэл хайр найргүй цээрлүүлнэ. Хамгийн түгээмэл цээр нь алах, тэдэнд өөр цээрлүүлэх арга хэрэгсэл байдаггүй. Өчүүхэн төдий сэжиг төрүүллээ гэхэд бас л ална, тэдэнд мөрдөн байцаах ямар ч арга хэрэгсэл байдаггүй.

Эрүүгийн үндэс бол удамшлын үндэс, хүн болгонд зоолттой байгаа. Төрийн сахилга бат, дэг журмын эрх ашгийн үүднээс тэр үндсийг тасдаж, үгүй хийж байвал зохино. Гэхдээ эрүүгийн үндэс энэ Кремлийн ордонд өнөөдөр болж байгаа шиг, шоронгоос оргосон хулгайчийн тухай ид хавтай дууны байдлаар, ширээн дээр бүжиглэх байдлаар, ийм гэм халгүй байдлаар оволзон гарч ирвэл... Одоо яая гэхэв, эрүүгийн үндэсний ийм илрэлтэй эвлэрч болно. тэрээр өчүүхэн төдий гэмийг ч маш хатуу шийтгэдэг, гэхдээ хүмүүс түүний баярт оролцохоор ирсэн бол баярлаж хөөрч, цэнгэж баясах ёстой.

Энэ хүлээн авалтын тухайд нөхөр Сталин сэтгэл хангалуун үлдэв. Улс үнэн санаанаасаа хөгжилдсөн, чин сэтгэлээсээ хөгжилдсөн. Хүмүүс хөгжилдөж байгаа бол ажил явдал нь сайн байна гэсэн үг. Улс оронд хүмүүс нь хөгжилдөж байгаа бол, чин сэтгэлээсээ хөгжилдөж байгаа бол улс орны ажил бас сайн байна гэсэн үг.

Бүлэг нэг эгнээгээр, байр нь зай муутай бол хоёр эгнээгээр жагсаж, Семён Григорьевич өмнө нь зогсоод удирдана:

– Баруун хөлөөсөө эхэлнэ шүү... Урагш алх — нэ-эг! Зүүн хөлөө — хо-ёр! Баруун хөлөө баруун тийш нь, зүүнийгээ шилжүүлж гишгэ — гу-рав! Дахиад баруун хөлөөрөө — дө-рөв! Аль хөл сул байгаа билээ? Зүүн хөл! Зүүн хөлөөсөө эхлэе. Урагшаа — нэг, хо-ёр! Хажуу тийш нь — гурав, дө-рөв! Саяныхаа хөдөлгөөнийг арагш нь хийе: баруунаараа, зүүнээрээ — нэг, хо-ёр! Баруун тийш, зүүн тийш — гурав, дө-рөв! Анхныхаа байдалд орцгоолоо.

Фокстрот, румба, тангоны үндэс болсон энэ хөдөлгөөнийг олон дахин давтана. Дараа нь энэ бүгдийгээ хөгжимтэй, фокстрот юмуу румбын тод хэмт хөгжимтэй сургуулилна. Баруун хөлөө урагш — нэг, хоёр, баруун тийш нь — гурав, дөрөв!.. Нэг, хоёр, гурав, дөрөв!.. “Улам дээшээ, дээшээ, манай шувуудын нислэг дээшээ тэмүүлнэ...” Нэг, хоёр, гурав, дөрөв!.. “Онгоцны сэнс болгонд манай хилийн тайван байдал амьсгалж байна...” Нэг, хоёр, гурав, дөрөв! Хөдөлгөөнийг өөрийн болгож эзэмшсэнийг баттай мэдмэгц, Семён Григорьевич түүнийгээ хос хосоороо хий гэж тушаана.

Семён Григорьевич тун буурьтай харагдана. Бадриун, бараг бүдүүн гэхээр дунд хэрийн насны хүн. Буурал сууж яваа өтгөн халимагтай, сахлаа мөлчийтөл хуссан гоё царайтай. Заавал хар костюмтай, цагаан цамцтай, эрвээхэй зангиатай, чийтэй гялалзсан хар шаахайтай хичээлд ирнэ. Гялалзсан том дугуй балдагтай, бас чийдмэл хар таяг тулж явна. Хичээлийн үед хүн хүрч унагахаас сэргийлэн таягаа алсын буланд тавина. Семён Григорьевич сайхан уянгалаг дуутай, нухацтай, жинтэй ярина, оршил яриандаа, Глебийн хэлж байсанчлан, бүжиг эрүүл мэндэд ашигтай, уран сайхны мэдрэхүй, хөгжмийн ухаарлыг хөгжүүлдэг гэж нотолсон Сократ, Аристотель нараас иш татна.

Өрнөдийн бүжгийг хөрөнгөтнийх мэтээр буруу тайлбарладаг, үнэн хэрэгтээ бол ардын гаралтай урлаг гэж Семён Григорьевич нотлоно. Танго бол Аргентины ардын бүжиг, румба — Мексикийнх, удаан фокстротыг ер нь блюзний аяар бүжиглэнэ, энэ бол америк негрүүдийн гунигт аялгуу. Энэ бол хэдэн зуунаар боолчлогдсон, эдүгээ ч хөрөнгөтний нийгмийн дарлал мөлжлөгт байгаа АНУ-ын негр хүн амын гуниг.

Саша Семён Григорьевичид өөрт нь бас түүний лекц ярианд егөөдөнгүй хандана. “Овжин эр”. Таягаа тулаад, үйлдвэр заводын үйлдвэрчний хорооны босго элээгээд явна, гэрээ хэлцэл байгуулна, тохьтой томоотой дүр эсгэж байгаад булхайлна. Ер нь яачихсан ч байж мэднэ. Аль ч хүнийг яаж ч мэднэ гэж бодох хэрэгтэй, одоо бүгдээрээ тэднийхэн. мань хүн ч гэсэн Тухачевскийг буудан алахыг зөвшөөрч гар өргөсөн болохоор гэм буруугүй хүмүүсийг алсны хариуцлагыг тэдэнтэй хуваалцана. Нөгөө нэг цуглааны тухай, хамаг биеийг эзэмдсэн айдасны тухай дурсамж эдүгээ өөрийг нь дарамталж, өөрөөсөө жигшихдээ хүрч, хорвоо ертөнцийг ингэж бүтээсэн гэж өөртөө итгүүлэхийг оролдовч, чухамхүү өөрөө л ингэж бүтээгдсэнээ ойлгож байлаа.

Хэн ч хэнд ч итгэхээ больсон, мань хүн ч бас итгэхгүй, хэнтэй ч улс төр, тэр ч атугай, сонинд

бичиж байгаа юмны талаар ч ярихгүй байгаа... “Тийм үү? Би уншаагүй л дээ... Харалгүй өнгөрсөн байх...” гэх жишээтэй. мань хүн үнэндээ ч бараг сонин уншихгүй байгаа, гудамжаар явж байхдаа самбарын “Правда”-г хаа нэгтээ харзнан зогсохоос цаашгүй. Дандаа л адилхан юм бичсэн байх: ялгуусан тодорхойлолтууд, хөдөлмөрийн дээд амжилтууд, аугаа их Сталинд дэвшүүлсэн мэндчилгээнүүд, түүний хөрөгнүүд, тагнуул, хорлон сүйтгэгчид, троцкистуудийг илчилсэн явдлууд, буудан хороосон ялнууд, шүүх хурлууд, “ард түмний дайсантай тэмцэхэд онцгой гавьяа” байгуулсны учир улсын аюулгүй байдлын ажилтан нарыг одонгоор шагнасан тухай гэх мэт. Шагнагдагсдын нэг удаагийн нэрсийн жагсаалтад Улаан таван хошуу одонгоор шагнуулсан Юрий Денисович Шарокийн нэр байхыг Саша харжээ.

Будягин, Марк хоёрыг буудан алсан, Октябрийн хувьсгалыг хийсэн намын удирдагч нар, иргэний дайны баатруудыг хуу хядсан, гэтэл хувьсгалын эсэргүүчүүд, зөвлөлтийг адлагчид өөрсдийн үгүй хийсэн намын нэрийн өмнөөс, нэгэнт байхгүй болсон ажилчин, тариачны засгийн өмнөөс одон тэмдгээр шагнуулж байна. Сталин хэний дарангуйллыг хэрэгжүүлж байна вэ? Пролетари нарт эрх мэдэл алга. Тариачин анги хамтралчид нэртэй хамжлагынхан болж хувираад байна. Төрийн албан хаагчид айдсын дунд амьдарч байна. Улс оронд Сталины, зөвхөн Сталины, ганцхан Сталины дарангуйлал л байна. Дарангуйлагч бол ангийн хүсэл зоригийг илэрхийлж болно гэсэн Лениний нотломж буруу, дарангуйлагч зөвхөн өөрийнхөө хүсэл зоригийг л илэрхийлж чадна, эс тэгвээс тэр дарангуйлагч биш.

Сашагийн нүдэнд Вадим Марасевичийн нэг өгүүлэл өртжээ. За ингээд Вадик хүртэл “Правда” сонинд юмаа нийтлүүлж, ямар нэг романыг бут ниргэж, зохиогчийг нь нударганчуудыг өмөөрсөн гэж яллаж байдаг байна. Вадим: “Зохиогч тэгж хүссэн эсэхийг үл харгалзан, роман нь олон улсын империализмд сайхан идэш болж, зөвлөлтийн хүмүүсийг оюун санааны хувьд ялзруулахад нь империализмд туслаж, Ленин-Сталины их үйл хэрэгт тэдний итгэх итгэлийг бусниулж байна” гэж бичжээ. Яллахаа ч хат даа, тэгж яривал 58 дугаар зүйл анги л ханхалж байна, яг шүү. Профессорын хүү гээд байгаа!

Бүгд янхандаж, бүгд өөрсдийгөө худалджээ. Бүх нийтийн айдас бүх нийтийн шившигт занг төрүүлж, бүх хүн хараанд орж, хаа л бол тэдний нүд, тэдний чих, хаа л бол боловсон хүчний хэлтэс, биеийн байцаал, хаа л бол паспорт шаардана, тэр паспортонд чиний хэн гэдэг нь тодорхой байгаа.

Тэгэхээр зөв сонголт хийжээ. Нийтийн бүжиг! Энд намтар шаардахгүй, биеийн байцаал бөглөх хэрэгцээ байхгүй. Болгоомжтой байх юм бол юмны аманд орчихгүй. Глебийн амлаад байсан албан томилолтыг байрны эзэгтэй нэхэхгүй байна, бодвол мартсан байх. Саша оройтож ирнэ, орой босно, ерөөсөө ирэхгүй байх нь ч элбэг, номхон томоотой аж төрнө, түүн дээр ирэх хүн амьтан байхгүй, байрныхаа хөлсийг хэл амгүй төлчихнө, эзэгтэйд өөр юм хэрэггүй. Үнэндээ бол, Мария Константиновна дээр паспорттайгаа очих хэрэгтэй гэж Глеб хэлсэн удаа бий, гэхдээ халт хэлсэн. Тийм учраас Саша энэ асуудлыг толгойноосоо авч хаясан, паспорт шаардахгүй байна, тэгээд л болоо биш үү.

тэрээр Уфад ирснийхээ дараа хамгийн анхны бүтэн сайнд л ээж рүүгээ утасдсан. Ээжийнх нь дуу түгшсэн шинжтэй байсан. Холбооны хүүхэн “Уфад хариулаарай” гэж хэлсэн.

– Сашенька, яагаад Уфа болчихов, юун Уфа вэ?

– Би авгын цуваагаар, томилолтоор Уфад явж байна, хоёр гурван сар болно, бид нар районуудаас тариа зөөх юм, тийм учраас тогтмол утасдаж чадахгүй байж мэднэ шүү. Гэхдээ хичээнэ ээ. Хуучин шигээ бүтэн сайнд л. Надад: Уфа, төв шуудан, өөрөө хүлээн авагч гэж хаяглаад бичээрэй.

Гэвч ээж нь ямар нэг барагтайхан юм мэдрээд, дахиад л түүний төлөө сэтгэл зовнин шаналаж байна.

– Яахаараа тийм хол явчдаг байна аа? Калинингаас Башкир руу?!

– Ээж ээ, тариа хураах кампанит ажлыг яаж хийхийг шийддэг нь та бид хоёр биш. Авгын цуваа явуул гэж тушааж, тэгээд л явуулсан байна. Санаа зовоод байх шалтгаан байхгүй.

– Верагийн нөхрийн ахынд очоорой. Би чамд хаягийг нь өгсөн шүү дээ.

– Цаг олдвол очно оо.

Саша дараагийн бүтэн сайнд нь ч бас ээж рүүгээ утасджээ. Тэгээд ээж нь тайвшрах шиг болж. Гэхдээ энд ч юмуу, эсвэл хувь тавилангаар шидэгдсэн өөр хаа нэгтээ дахиад баривчлагдвал ээж нь яана даа? 1934 онд түүнийг гэрээс нь баривчилсан, ээж нь Москвагийн шоронгуудаар хайсаар байж нэг юм олсон. Гэтэл Уфад ч юмуу, өөр хаа нэг газар өөрийг нь бариад авбал, ээж нь түүнийг хаагуур, яаж хайх вэ, амьд, үхсэн, баригдсан эсэхийг ч мэдэж чадахгүй, хаашаа явах, ямар шорон, ямар эмнэлэг, ямар оршуулгын газар руу харайлгахаа ч мэдэхгүй... Ингэвэл ч ээж минь тэсч гарахгүй дээ.

мань хүн Верагийн хамаатныд очсонгүй. түүнийг яаж хүлээж авахыг бүү мэд: ял эдэлж байсан хүнийг гэртээ оруулах чинь одоон цагт осолтой. Ер нь ч очих хэрэгцээ алга. тэрээр төвхнөж, энэ амар жимэр, бараг хөнгөн гэхээр амьдралдаа дасч байна. Калининд ачааныхаа машинаар газар хороож явахдаа толгойноос салахгүй нэгэн бодлыг мянгантаа эрэгцүүлж, сонины хуудас адган эргүүлж, ялангуяа гуниглаж ганцаардсан үдшийн цагаар цөхрөнгөө бардаг асан. Эндхийн үдэш бол баяр л гэсэн үг, хөгжим хангинаад, дарга нарыгаа, нам, үйлдвэрчний хороогоо, албаны лайгаа мартсан хөөрхөн хүүхнүүд нүд нь гялалзаад, өөрийнх нь үг болгоныг шүүрч аваад л.

– Баруун хөлөө урагш нь — нэ-эг! Зүүн хөлөө урагш нь — хо-ёр! “Маша цай аягалж байна, харц нь маш ихийг амлаж байна...” Нэг, хоёр, гурав, дөрөв! “Тулгат тогооны дэргэд Маша бидэн хоёр, өглөө болтол ёотон амтлан цай ууна...” Дугуйлангийнхан мэрийцгээж байна. Хараал идсэн ахуйгаа ч санаж байгаа юм алга, дараачийн цалин буутал мөнгө хүрэхгүйгээ ч бодож байгаа юм алга, хуу мартчихна... Дажгүй ажил, хүмүүс сэтгэлийн ханамж тааламж аваад л.

Саша бүлэг болгоноос нэг авьяаслаг охиныг сонгон авч, түүнийгээ туслагч болгон хөдөлгөөнийг хамтдаа үзүүлнэ. Бүр анхных нь бүлгээс л нэг тийм охин олдож. Арван зургаа хэрийн настай, гоолиг, уян налархай биетэй, хүүхэд шиг итгэмхий булбарай царайтай Гуля гэдэг охин. Хэм сайн мэдрэнэ, хөл хөнгөн, гар чанга, хамт бүжиглэгчээ бахим барина, хэрэгтэй зүгт нь ёсчлон эргүүлнэ, хамгийн мулгуу амьтантай ч найдвартай ажиллана. Семён

Григорьевич: “Манай уриа бол зуун хувийн амжилт гаргах явдал. Хүн болгон бүжиг сурч чадна — бүжиглэх авьяас хүнд байгалиас заяасан байдаг юм” хэмээн буурьтай сургамжлана.

Өөр рүү нь харж байгаа Гулягийн харцтай Саша байн байн тулгарч, тэр бүрийд охин ичингүйрэн хараа буруулж байгааг анзаарчээ. Ийм насны охид залуу багш нартаа дурлах нь элбэг байдаг болохоор мань хүн түүнд таалагддаг аж. Нэг удаа хамт бүжиглэж байхдаа Гуля эмээн хулган байж,

– Хичээлийн дараа театрт орох уу, энд, энэ Хөдөлмөрийн ордны дээд давхарт? гэж асуужээ.

Дээд давхарт үзэгчдийн танхимтай, тэнд концерт тавина, бас явуулын жүжигчид энэ тэр тоглоно.

Гуля энгэрийнхээ халааснаас хоёр тасалбар гаргаж,

– Надад тасалбар бэлээхэн байж байна гэжээ.

– Гуленька, баярлалаа, би даанч өнөөдөр хичээлийн дараа Аялан тоглолтын товчоон дээр зөвөлгөөнтэй, чи найз охинтойгоо үзчих.

Ямар ч хурал зөвөлгөөн байхгүй, Саша зүгээр л энэ охинтой амраглахыг хүссэнгүй.

тэрээр Варя “Арбатын нүх”-ний мөсөн гулгуур руу урьж байсныг эргэн санажээ. Яг л тийм гэнэн арга. мань хүн одоо Варягийн тухай хардлага сэрдлэггүй, гомдол саналгүй боддог болжээ. Бүх юм болдгоороо болоод өнгөрч. Тэр үед Варяд идрийн жавхаа байсан, Сибирьт өөрийнх нь ганцаардал байсан, ээжийнх нь захианы булан дээрх түүний бичсэн нэмээс байсан, өөр хэнээс ч захиа занга авч байгаагүй болохоор суллан тавигдахаа чухамхүү түүнтэй холбон боддог асан, Варя түүний хувьд өөрийнх нь Москва, өөрийнх нь Арбат, өөрийнх нь ирээдүй байсан. Бүх юмыг өөрөө бодож олж, бүх юмыг санаанаасаа зохиож байжээ. Тэглээ ч гэсэн шархыг хөндвөл өвддөг юм чинь. Тийм учраас мань хүн Варяг дурсан санахгүй байхыг хичээнэ. Гэхдээ нэг удаа ээжтэйгээ утсаар ярихдаа хэн орж гарч байгаа тухай асуужээ. Тийм асуулт тавина гэж бодоогүй байсан хэрнээ гэнэтхэн Варягийн нэрийг сонсмоор санагдсан аж.

– Хэн орж гарч байна гэж үү? хэмээн ээж нь лавлаж асууснаа, – Варя орж гарна, хоёр дүү маань хааяа үзэгдэнэ. Юу гэж? гэв.

– Зүгээр л чамайг яаж шуухан аж төрж байгаа бол гэж бодоод л асуусан юм.

Варя орж гардаг байх нь. Үүнийг дуулаад баярлажээ. Уул нь, сайн бодох юм бол ийм мэдээ юу ч хэлэхгүй байна л даа. Варягийн нэрийг сонсохыг хүссэн, тэгээд сонслоо. Ердөө л тэр.

Шарок Парис анх орсноосоо хойш дахин нэг орж, тэгтэл дараа нь түүнийг орос цагаач Юрий Александрович Приваловын Испаниас олдсон паспорттайгаар тэнд үлдээжээ. Азаар тэдний нэр таарсан хэрэг: талийгч ч, тэр ч нэр нь Юрий. Шинэ намтрыг сайхан зохиожээ. Хүүхэд байхдаа Шанхайд цагаачлан очиж таарсан; эцэг эх нь нас барсан; тэгээд Парист шилжиж ирсэн, зар сурталчилгааны пүүст ажилтай, эзэн нь франц хүн. Орост бол, Нальчик хотод холын хамаатнууд үлдсэн, тэдэнтэй, мэдээж, харилцаа холбоо байхгүй, ер нь амьд эсэхийг нь ч мэдэхгүй. Энэ нь дипломат “дээвэр” биш ч гэсэн найдвартай. Шпигельглас түүнд хоёр агенттай холбоотой байхыг итгэмжлэн зөвшөөрчээ: нэг нь генерал Скоблин (“Фермер”), нөгөө нь Третьяков (“Иванов”). Тухачевскийн хэргийг бэлтгэж байх үед Шарок Шпигельгласын хамт “Фермер”-тэй өмнө нь нэг бус удаа уулзаж байсан бол Третьяков — “Иванов”-ын хавтаст хэргийг Парист судалжээ.

Хувьсгалын өмнөх Оросын аж үйлдвэрийн томоохон эзэн, 1917 онд Түр засгийн газрын сайд, дараа нь Колчакийн засгийн газрын сайд байсан, 1930 онд сарын 200 доллараар зөвлөлтийн талд элссэн Сергей Николаевич Третьяков бол цагаачдын дунд нэр хүнд сайтай нэгэн. Гэхдээ агентын хувьд түүний гол үнэ цэнэ юу вэ гэхээр, Третьяковын байшингийн (Колизе-гийн гудамж, 29) нэгдүгээрт давхарт Оросын Нэгдсэн Цэргийн Холбооны (ОНЦХ) штаб байрладаг явдал юм. Третьяковын гэр бүл гуравдугаар давхарт суудаг, харин өөрөө бол хоёрдугаар давхарт, ОНЦХ-ны удирдагч генерал Миллерийн албан өрөөний яг дээр амьдрана. Энэхүү албан өрөөний таазанд чагнах төхөөрөг тавьсан бөгөөд Третьяков өдөржин сонголын аппараттай сууж, чагнасан зүйлээ тэмдэглээд, тэмдэглэлээ Шарокт дамжуулна. Тийнхүү зөвлөлтийн тагнуулын алба цагаантан цагаачдын тухай хамгийн нууц мэдээллийг авч байх бололцоотой болжээ.

Бас Третьяковтой уулзах нь Скоблинтой уулзахаас хавьгүй таатай. Скоблин ихэрхүү хямсаганана, бас түүнтэй уулзах нь осолтой: цагаачид түүнийг ДЯАК-тай хамтарч ажилладаг гэж сэжиглэдэг, мөрдөж мөшгиж байж болох учраас уулзах газар, цагийн товыг голдуу өөрчлөх хэрэг гарна. Третьяков сэжгээс гадуур учраас тэр хоёр лхагва гариг бүр таван цагийн алдад Плас де ла Бастиль, IV Генрихийн цэцэрлэгт гудам хоёрын булан дээр байдаг “Генрих IV” гэдэг цайны газар уулзаж, энэ үес хүнгүй шахуу байдаг жижгэвтэр танхимд сууцгаана. А ж л ы н х а а талаар хэзээ ч ярихгүй, авчирсан сэтгүүлүүдээ ширээн дээр тавина, Третьяков Шарокийн сэтгүүлийг, Шарок Третьяковын сэтгүүлийг авч одно, тэр сэтгүүлийн завсар сонссон ярианы тэмдэглэл байгаа.

Шпигельгласаас тухайн үедээ өгсөн анхааруулга бий:

– Третьяков цагаачдын тухайд урам хугарсан, гэхдээ өөрт байгаа мэдээллээ бүрэн өгдөггүй хүн. Тийм учраас илүү юм шаардан, чамлаж байгаагаа байнга харуулж байх хэрэгтэй. Тэр зөвхөн мөнгөний төлөө ажиллаж байгаа, тэгэхээр та нараас мөнгө салгах гэж элдвээр царайчилж, гуйж гувшина. Тийм юманд автаж болохгүй. Сард 200 доллар, ганц цент ч илүү бүү өг. Муу ажиллавал зууг өгч бай, гайгүй юм мэдээлвэл үлдсэнийг нь өгч бай. Гарын үсэг заавал авна шүү. Өнгөрсний тухай ярианаас нь онцгой болгоомжтой бай, хуучны тухай ярих дуртай, та нарыг уяраачихна гэж мэдээрэй.

Гэхдээ Шарок Третьяковын тухайд сэтгэл хангалуун байв. Скоблиных товчхон, саланги тасархай, тэр болгон чухал биш мэдээлэл байдаг бол Третьяков дорвитой, дэлгэрэнгүй мэдээлэл өгнө. Нуруулаг, данагар сайхан орос ноёнтон хувьсгалын өмнөх Оросын тухай, хуучин Москвагийн тухай амтархан хуучлах зуур кофе оочлоно. Шарок Шпигельгласын зөвөлгөөг эс харгалзан түүний яриаг ерөөс эс тасдана. Сонсохгүй байхын учир юу сан билээ? Тийн сонсохын хамт өвгөнийг ажиглан, сэтгэл санаа нь хувирамтгай гэхчилэн хувийн дүгнэлт хийнэ. Гэнэт сайхан инээмсэглэснээ дорхноо больж, хөмсөг зангидан царай нь барайгаад, цагаачдыг зүхээд эхлэнэ:

– Зөвлөлүүдтэй тэмцэх утгаар аливаа ач холбогдлоо алдлаа, хоорондоо л хэмлэлдэж байна. Гадаадын гүрнүүд тэдэнд найдахаа больчихлоо. Талийгаачдаар бооцоо тавих ч биш дээ.

Шарок Третьяковтой уулзахдаа дөч орчим минут гаргадаг бөгөөд удахгүй түүнтэй хормын төдий ч салахгүй бараг хоёр хоног хамт өнгөрөөнө гэж яахин зүүдлэх сэн билээ. Энэ явдал Миллерийг хулгайлах үеэр тохиожээ. Тухачевский болон зөвлөлтийн бусад цэргийн дарга нарын хэрэгт Скоблин ямар үүрэг гүйцэтгэснийг Миллер мэдэж байжээ. Шпигельглас чухамхүү энэ учраас түүнийг хүсэмгүй гэрч хэмээн үзэж, Скоблины хамт түүнийг хулгайлах ажиллагааг бэлтгэж, есдүгээр сарын 22-нд хийхээр товлосон аж. Скоблин яг энэ ажилбар дээр баларчээ.

Генерал Миллер штабаасаа гарахын өмнө битүүмжилсэн дугтуй үлдээж, өөрийг нь орой гэхэд эргэж ирэхгүй бол нээж үз гэж тушаасан юмсанж.

Миллер эргэж ирсэнгүй, дугтуйг нээвэл дотор нь дараахь зурвас байжээ:

“Би өнөөдөр 12 цаг 30 минутад Jasmin, Raffet хоёр гудамжны булан дээр генерал Скоблинтой уулзах болзоотой. Тэр намайг германы хоёр офицертой уулзуулахаар авч явах ёстой: хурандаа Штромаан, Германы эндхийн элчин сайдын яамны ажилман Вернер хоёртой. Уулзалтыг Скоблины санаачлагаар зохион байгуулж байгаа болно. Энэ урхи байж магадгүй учраас та бүхэнд энэ зурвасыг үлдээж байна”.

Миллерийн ажилтнууд уг зурвасыг Скоблинд үзүүлээд, хамтдаа цагдаагийн газар очихыг санал болгожээ. Гэтэл Скоблин бултаж, Шпигельгластай холбоо барьж дөнгөжээ. Цаадах нь түүнийг Третьяковын, өөрөөр хэлбэл, ОБНЦХ-ны штаб байгаа байшинд бүгүүл, тэнд түүнийг хайна гэж хэний ч толгойд орж ирэхгүй гэж Шарокт тушаасан байна. Шпигельглас хоёр хоногийн дараа Скоблиныг Испани руу гаргаад, өөрөө Москва яваад өгчээ.

Третьяков Скоблиныг хараад балмагдан айсан бол Миллерийг хулгайлахад түүний оролцсоныг маргааш нь сониноос олж мэдээд, бүр үнхэлцэг нь хагарах шахжээ — тэрээр Скоблиныг гэртээ бүгүүлснээр гэмт хэргийн хамсаатан болсон байна. Шарок өвгөнийг элдвээр тайвшруулан, хоёр хоног цурам хийлгүй хянаж байгаад, Скоблиныг Испани руу гаргамагц энэ ажлыг нь үнэлэн таван зуун доллар өгчээ. Шпигельглас тэгж тушаасан хэрэг. Третьяков ч тайвширлаа, энэ хэрэг явдалтай холбогдон түүний нэрийг хаана ч, хэн ч дурсаагүйг ч хэлэх үү, тэрээр хуучны адил хардлагын гадна үлджээ.

Миллерийг хулгайлсны нарийн ширийнийг Шарок сониноос олж үзэв. Скоблин Миллерийг

Монморансийн цэцэрлэгт гудамны нэгэн шилтгээний үүдэнд авчрахад, хоёр хүн түүнийг машинд түлхэж оруулаад, тэр даруй Гавр боомтын зүг довтолгожээ. Гаврт ирээд, Миллерийг нуусан хайрцгийг зөвлөлтийн “Мария Ульянова” гэдэг усан онгоцонд шилжүүлэн ачсанд сайхь онгоц даруй занга юугаа эвхэн Ленинградын зүг явж одсон аж. Генерал Миллерийн цаашдын хувь заяаны талаар Шарок таамаг тавихаас цааш гарсангүй — гарцаагүй буудан алсан даа.

Шарок сонин хэвлэлийг анхааралтай уншаад дотроо жуумалзана: бөөн шуугиан, орь дуу. Большевикууд Францын нутаг дэвсгэр дээр гэгээн цагаан өдөр хүн хулгайлж байна! Генерал Кутеповыг хулгайлж байсан бол, одоо генерал Миллерийг! Миллерийг Гаврт хүргэсэн ачааны машин Зөвлөлтийн элчин сайдын яамных юм байна. Энэ ажилд тухайн үедээ өдөөн хөтгөгч Азефийг илчилсэн алдарт Бурцев оролцсон байна. Бурцев Москвагийн гол агент бол Скоблин биш, түүний авгай — Оросын нэрт дуучин Плевицкая, Скоблин түүний дэргэд хоёрдугаар зэргийн үүрэгтэй гэж нотолдог. Плевицкаяг баривчилсан, шоронд суугаад шүүх хурлыг хүлээж байгаа. Байдал улам хурцадсаар, Шпигельглас болон зарим нэг суурин агент Москвад бүгж байв. Сайтар нууцлагдсан Шарок Парист үлджээ. Элдэв ажлын хажуугаар герман хэлээ үзнэ.

Шпигельглас түүнд, яаж байгаад ч билээ, нэг удаа

– Тагнуулч дор хаяхад хоёр хэл мэдэх ёстой. Та дунд сургуульд франц хэл, дээд сургуульд герман хэл үзэж байж, таны биеийн байцаалд тэгж бичсэн байна гэж хэлжээ.

– Тийм шүү, дээд сургуульд герман хэл үзэж байсан.

– Тэгвэл түүнийгээ одоо яг үз. Танай эзэн эльзас хүн, авгай нь герман, бас германаар ярьцгаана, танд сайхан практик болно.

Тоглоом болгосхийсэн хэрнээ,

– Хичээнгүй үзнэ шүү, бид шалгана гэж учиртай гэгч нь хэлээд, – Өөр бас нэг юм байна: цагаачидтай ахуйн түвшинд холбоо харилцаа тогтоо, хэрэгтэй бол ажил хэргийн, арилжааны түвшинд ч болно. Танд “Өө, Юрий Александрович уу... бид түүнийг мэдэлгүй яахав” гэж гэрчилж чадах танил хүмүүсийн хүрээ байх ёстой. Заавал цол хэргэмтэй гэх албагүй жирийн хүмүүс ч байсан болно гэжээ.

– Жирийн цагаачдын дунд ч ноёд бий гэж Шарок хариуд нь бас тоглон өгүүлжээ.

– Энэ чинь ч бас тохирно.

Семён Григорьевич дахиад хоёр хамсал хөгжимчин урьсан нь төгөлдөр хуурч, баян хуурч хоёр аж. Баян хуурч нь цайлган сэтгэлтэй, хүнд үгүй гэж чаддаггүй, дуулгавартай Лёня гэдэг булиа залуу баян хуураа чирээд хаа яв гэсэн газар очно, сонсголоороо тоглоно, дардаг хээ шаагүй хэдхэн аятай, юм балгана, энэ утгаараа Глебт, зөвхөн түүнд ч төдийгүй Сашад ч бас хань болно, Саша сүүлийн үед балгадаг, заримдаа яггүй балгадаг болоод байгаа. Төгөлдөр хуурч нь Миша Каневский гэдэг туранхай, татвалзсан нүүртэй, түгшсэн бор нүдтэй, гоё урт хуруутай мэрэгжлийн хүн, Ленинградын хөгжмийн дээд сургуульд сурч байгаад төгсөлгүй Уфад ирж таараад, Аялан тоглогчдын товчоонд орсон, ажил багатай байсан учир Семён Григорьевичийн саналыг хүлээж авчээ. Рестораны найрал хөгжимд орохоос,

– “Тэд нар” намайг рестораны барлаг болгож чадахгүй гээд татгалзжээ. Царайд нь харамсаж адалсан мишээл үе үе тэнүүчилж, тамшаалж ярвайна.

Мишаг Кировыг алсны дараа хэдэн мянган “хөрөнгөтний болон тайж язгууртны төлөөлөгчдийн” хамт Ленинградаас цөлжээ. Эцэг нь хувьсгалаас өмнө Санкт-Петербургт хувийн байшинтай өмгөөлөгч байсан аж. Хувьсгалын дараа байшинг нь хураан авч, мань өмгөөлөгч “байшингийн томоохон эзэнтэн агчдын” тоонд орж, Миша “байшингийн томоохон эзэн агчийн хүү” гэсэн данстай болжээ. Уфад тийм залуус олон байсан, тэдний байдал тодорхойгүй, зөвхөн Ленинградынх нь бүртгэлийг нь устгаад паспортыг нь хурааж аваагүй. Каневский ирээдүйгээ, мэдээж, тэс өөрөөр төсөөлж асан, тэгтэл “тэдний” өршөөлөөр Уфад ирж, хөлсний хөгжимчин болжээ. тэрээр энэ хотын бүх юмыг үзэн ядна: “тэдний” клубыг, “тэдний” аль хэдийн хөглөх болчихсон, гэхдээ ичих нүүргүйчүүд нь үүнийгээ ойлгодоггүй их бага гарын төгөлдөр хуурыг, “тэдний” ханан дээрх уриа дуудлагыг, өөрийнх нь тоглох ёстой болдог “тэдний” орчин үеийн бузар аяыг гэхчлэн бүгдий нь үзэн ядна. Дотроо бол Глеб, Лёня хоёрыг эд нарын хөгжимчин гэж юу байхав хэмээн, Семён Григорьевич, Нонна, Саша гурвыг мөнгө халааслахаас цаашгүй оронцоглогчид хэмээн ад үзнэ. Тэднээс хөндий байна, юм ч ярихгүй, тэр ч бүү хэл, тусдаа зогсож байгаад тамхи татна. Хичээл дуусангуут нүд ирмэхийн зуур алга болоод өгнө.

Глеб түүнд дургүй нь хүрсэн учраас тун хүйтэн харьцана. Сашад нэг удаа,

– Еврейн сэхээтний ихэмсэг занг би тэвчиж чаддаггүй юм гэж хэлсэн.

– Чи чинь еврейн эсрэг үзэлтэн байх нь ээ? Санаанд ороогүй юм байна.

– Би еврейн эсрэг үзэлтэн биш, ялдам минь, сургуульд ч, техникумд ч миний бүх найз еврей байсан. Байрны хөршүүд ч бас еврей, маш сайхан улс! Бас багш нарын дотор ч олон еврей байсан, тийм багш нарыг эрээд ч олохгүй! Гэхдээ ард түмэн болгонд өөрийн гэсэн дутагдал бий, еврейн сэхээтнүүдийнх бол — ихэмсэг зан. Каневский өөрийнхөө тухай их юм ойлгоно, өөрийгөө суу билэгтэн гэж үзэж байна.

– “Энэ бол армян”, “энэ бол хохоол”, “энэ бол гүрж” гэх маягийн юмыг чинь сонсохоос муухай байна. Иванов хулгай хийвэл чи: “Иванов хулгайч” гэж хэлнэ. Харин Рабинович хулгай хийвэл чи: “Еврей хулгайч” гэж хэлнэ.

– Нүдэнд хүйтэн золиг.

– Золиг чинь чи! Тэр чинь зол заяагүй, хөөгдөж туугдаж яваа хүн.

Глеб хичээлийн үеэр Сашагийн зүг байн байн хараад байсан нь Каневскийн тухай ярианаас хойш өөрөө буруутан оргиод байгаагаа мэдэрснийх байж. Дараа нь энэ тухай бодохоо больж, хөгжмийн хэмээр толгойгоо дохин тоглохдоо ямар нэг юм нэхэн санасан бололтой царай нь номхрон, харц нь эзэнгүйрсэн харагдана. Хичээл дууссан боловч мань хүн гараа өвдөг дээрээ тавьчихаад, төгөлдөр хуурынхаа ард суусаар байв. Тэгснээ, Саша руу нааш ир гэж дохив.

– Хамгийн эгэл аялгуу, хамгийн энгийн үгс сэтгэл сэргээдгийг чи анзаарчээ, ялдам минь. Ямар ч уран хэцүү хөдөлгөөн хэрэггүй, гэхдээ “санаж байна уу” гэдэг үг байгууштай юм. Тэгэх юм бол хэн ч тэсэхгүй дээ, ялдам минь.

– Жишээ нь?

– Бололгүй яахав, бүр чиний нэрийг оруулаад: “Саша, чи далайн эргийн цэцэрлэгт хүрээлэнд уулзаж байснаа санаж байна уу. Саша, чи тэр намуухан үдшийг, тэр хаврын үдшийг, өвч цэцэглэсэн туулайн бөөрийг санаж байна уу”. Энэ бол Изабелла Юрьевагийнх. Тэгвэл Лещенко: “Москвад, Масленая гудамнаа хуучин цагт яаж бин хайрч байснаа чи санаж байна уу, чи сайхан зантай эзэгтэй байсан, надад амтат бин хайрч өгч асан” гэсэн байгаа. За, гэх мэт.

Саша хэдийн биеэ даан хичээл удирдах болж, оршил үг энэ тэрдээ Семён Григорьевичийг дууриаж Сократ, Аристотель нараас бус харин Пушкинээс иш татна:

Галзуу залуу насанд би хайртай,

Шахцалдаанд ч, амьдралд ч, баяр хөөрт ч,

Авхайчуулын учирлаг өмсгөлд ч би дуртай;

Тэдний хөөрхөн хөлд би дуртай; даанч та нар,

Бүхэл Орос даяараас хүүхний гурван хос

Цэх шулуун шилбийг олох нь юу л бол.

Ийнхүү ишлээд, – Хэрвээ Пушкин манай хичээл дээр ирдэг сэн бол Орост цэх шулуун хөл хавьгүй олон юм байна гэж итгэх байсан даа хэмээн үгээ төгсгөнө.

Бүгд инээмсэглэн урамшиж, Саша ч хичээлээ эхлэнэ.

–Чи тэр Пушкины тухай дажгүй бодож олсон байна хэмээн Глеб сайшаав.

Ярианд оролцдоггүй зантай Каневский,

– Цаг үеэ сүрхий олж гэм. Пушкины амиа алдсаны зуун жилийн ойг тэмдэглэцгээсэн, одоо зөвлөлтийн бүх хүн түүнийг мэднэ. Саальчин ч билүү, гахайчин ч билүү, санахгүй байна, нэг хүүхэн: “Татьяна ёстой мундаг: Онегинийг хөөчихсөн байна. Хээ шаагүй, хөдөө сууж байхад нь түүнийг тоогоогүй. Генералын авгай болчихсон чинь шууд хэрэгтэй болж гэнэ” гэж хэлснийг сониноос уншсан шүү гээд сурсан зангаараа харамсаж адалсан царайтай хямсалзаад дуугүй болов.

Энд түүнтэй эрхбиш наанатай цаанатай нөхөрсөг харилцаатай болсон нь ганц Саша. Бардамаасаа болж хөөрхийлэлтэй, дотроо өшиж хорссон, арчаагүй тэр амьтныг Саша өрөвдөнө. Каневский түүний энэ сэтгэлийг мэдрэн, ганц нэг үгний солиотой байдгаас гадна чухамхүү түүнд хэнээс ч дуртай хамсан хөгжимдөнө. Гэтэл өнөөдөр биеэ барьж чадсангүй. Энэ явдал төрийн түвшинд хуурамчаар сүр бадруулан тэмдэглэсэн Пушкины ойн баяр ёслолтой дэндүү давхцаж таарч л дээ. Энд, энэ оронцогийн ажилд түүний алдрыг ашиглаж байх ёстой юмуу? Нийтийн аясыг даган таваргаж байгаагаа Саша өөрөө ч мэдээд байгаа билээ. Гэтэл хичээлдээ ийм баяр хөөртэй оршил хийхээс татгалзахад хайран байж. Хөрөнгөтнүүд Америкийн негр хүн амыг мөлжиж байгаа тухай донгосоод байх уу? Үгүй ээ, бүжигт наадмын тухай, шахцалдаан, амьдралын тухай Пушкины шүлэг энд илүү тохирно.

– Каневский чамайг хөөрхөн чимхлээ шүү гэж Глеб өгүүлэв.

– Яаж тэр билээ?

– Яахав, Пушкинаар... Засгийнхан Пушкиныг ашиглаж байна, чамайг тэдэнтэй хамсаж байна гэх маягаар.

–За яахав, тэгж санагдаж болох л юм.

– Хүн болгонд биш шүү, ялдам минь. Надад бол тэгж санагдаагүй, харин ч таалагдсан. Харин цаадахад чинь бол үгүй. “Гахайчин”, “саальчин”... Энэ чинь тэр гахайчин, саальчин хүүхнүүдийг харсан юмуу? Аягүй бол сүү уудаг даа, тийм хэрнээ саальчдыг ад үзэж байна. Тэр муу ганц удаа ч болохноо тэдний гарыг хараасай. Хөөмөл мойного хуруутай, тийм хуруугаар төгөлдөр хуурын даруулыг тоншихгүй байлгүй, үнээ саах гээд үз, тэгвэл ямар хүч ордгийг ухаарна.

– Энэ Каневский чамайг яачихаав! Төгөлдөр хуур чамаас доргүй тоглодог нь дургүйг чинь хүргээд байгаа юм уу?

– Тэр чинь надаас дээр тоглох үүрэгтэй, хөгжмийн дээдэд сурч байсан хүн, би бол хаа ч ном үзээгүй, тэгээд ч би зураач болохоос хөгжимчин биш. Миний дургүй байгаа юм бол өөр, бид энүүнээс болж шоронд сууна гэхээс дургүй хүрээд байна. Миний дургүй байгаа юм бол тэр.

Саша дал мөрөө хавчив.

– Тийм шүү, ялдам минь, бодоод үз! Тэр чинь: Ширэн нүүртнүүд Пушкинаас зуурчихлаа гэж түүний талаар доогтой ярьж байна.

– Тийм утга хайхын хэрэг юу байна? Ямар ч үгийг мушгиж болно.

– Ялдам минь, би юу ч мушгиж гуйвуулаагүй байна. Одоогийн ярьдгаар, би сонор сэрэмжтэй байх албатай, дөрөөн дээрээ байх ёстой, миний хажууд хэн байна, тэр яаж болзошгүй тухай бодож байх ёстой. Ийм цаг үе, ялдам минь, чи бол бүр ч тэгж байх албатай. Калининд байхдаа чи хуучин хоригдол гэдгээ мэдэрч болгоомжтой байсан, энд бол мартчихсан байна, тэгж байгаад л хэрэгт орчихно гэж мэд. Ингэхэд, чи ч аль Калининд байхын л сонор сэрэмжээ гээчихсэн л дээ.

– Яг яаж тэр вэ?

– Би тэнд, “Селигер”-т сууж байхад чамд дэглэмийн талаар сэрэмжлүүлж хэлсэн. Чи шууд л маргааш нь тэр балиар баазаасаа халагдаж, надтай хамт тэндээс талийж өгөх ёстой байсан. Гэтэл чи үлдчихсэн.

– Энэ тухай чи бид хоёр аль хэдийн ярьсан. Хэдхэн хоногийн дараа л халагдсан юм чинь.

– Үгүй ээ, ялдам минь, үгүй шүү. Халагдаагүй, халсан. “Явж байгаа учир” гэдэг чинь эсвэл шоронд хийсэн, эсвэл хотоос хөөсөн гэсэн үг. Харин ч чи азтай мултарч. Зүгээр оршин суух эрхийг чинь хасах төдийгүй хөөчихөж ч чадах байсан. Даанч тэд нар хугацаанд шахагдсан байх, тэгээд хэнийг хааш нь яахав энэ тэр гэх зав байсангүй, бүгдий нь бөөнд нь хотоос тонилгоё, тэгээд л гүйцээ гэж л дээ. Даалгавраа биелүүлчих нь тэр!

– Би чамтай хамт явсан бол юу болох байсан нь бас тодорхойгүй. Одоо бол миний бүх юм номоороо байна: ажлаасаа халагдсан, оршин суух газрынхаа бүртгэлээс хасуулсан.

– Хасуулсан гэнэ! Тэгвэл одоо хаана бүртгэлтэй байна? Завдахгүй байна уу? Чиний хайртай Пушкин: “Өвөл, тариачин жаргалаа эдлэнэ, дахаа хэдрээд, юуг ч эс тооно” гэж бичив дээ. Чи бас юуг ч тоохгүй байна! Амар жимэр аж төрөөд л. Гэтэл энд, энэ башкируудтай зодолдож таарая гэж сана, цагдаа хүрээд ирнэ, баримт бичгээ үзүүл мүүзүүл л болно! Таны бүртгэл хаана байна? Хаана ч алга. Манай энд гурав хоногоос илүү бүртгэлгүй байж болохгүй. Та чинь бүгж байгаа юм биш биз, та чинь гэмт хэрэгтэн биш биз? Чи одоо бүртгэлгүй хэдэн сар болж байна, нэг мэдэхэд чинь хагас жил, тэгээд жил болчихно. Өөр хотод очоод бүртгүүлэх боллоо гэхэд чамаас хаана тэнэж явсан юм бэ гэж асууна. Юу гэж хэлэхэв? Шинэ газар өөр Людка, өөр паспортын Лиза олдохгүй ч байж мэднэ. Энд ч гэсэн Товчооны Мария Константиновна паспортыг чинь харвал: та бүртгэлгүй юм байна, таныг данснаас хаслаа гээд л гүйцнэ. Ингэхэд, ялдам минь, би чамд Мария Константиновна дээр паспорттойгоо оч гэж хэлсэн. Хэлсэн үү?

– Нээрэн, тэгсэн, гэхдээ халыг л хэлсэн.

– Хөөе юу гэнэ ээ, ялдам аа, чи надад утас ороож байх шив... Би чинь дамар биш шүү! “Халыг” гэдэг чинь юу гэсэн үг вэ? Чиний хувьд “халыг” юм гэж байж болохгүй, бүх юм чухал, бүх юмыг дор нь тусгаж авч, хөдөлж байх хэрэгтэй! Саша хөмсөг зангидан,

– Энэ тухай яриад ч яахав. Би Калинин явахгүй, тэнд миний бүртгэлээс хасуулсныг хэн ч

хүчингүй болгохгүй. Эндээ л нэг юм бодож олохоос гэв.

– Яагаад өөрөө бодохгүй өдий хүрсэн юм? Чи ноцтой хэрэгт орж байсан ч гэсэн аз чинь таараад мултардаг байсан бололтой юм. Аз чинь таарахгүй ч байж болно, бүр заяа чинь ч хаяж мэднэ, тийм учраас болгоомжтой бай.

Глебийн сануулга ердөө маргааш нь ёсоор боллоо, шулам шүгэлсэн юм уу, эсвэл урьдаас мэдэж байсан юм уу?

Саша өглөө гар нүүрээ угааж байсан чинь гэрийн эзэгтэй ирж,

– Александр Павлович, өчигдөр сонгуулийн хэсгийнхэн ирсэн, тэдэнтэй хамт байрны захиргааны паспорт хариуцсан хүүхэн явна лээ. Дээд Зөвлөлийн сонгуульд санал өгөх хүмүүсийн жагсаалт гаргаж байгаа гэнэ. Арван хоёрдугаар сард бүх нийтийн сонгууль болно, сониноос уншсан байлгүй гэжээ.

– Уншсан, мэдэлгүй яахав.

Зүрх нь дахиад л, нэгэн цагт тэгсэн шигээ муухай гөхөлзөөд явчихав.

– Оршин суугчдын жагсаалт гаргаж байгаа гэнэ. Бүгдий нь заавал зуун хувь санал өгүүлэх гэж тэр. Би таныг Александр Павлович Панкратов, жүжигчин, Аялан тоглогчдын товчооны томилолтоор байгаа гээд бүртгүүлчихсэн. Тэгсэн чинь паспортын хүүхэн миний дундуур орж: “Та надад тэр хүний ямар ч томилолтыг өгөөгүй” гэдэг байгаа. Александр Павлович, та надад томилолтоо өгсөн бил үү, би мартчихаж.

Саша дэмий л түгдрэн,

– Санахгүй байна... Би анх манай нөхөртэй ирэхдээ тэндээс нэг бичиг авчирсан санагдах юм.

– Би нэг тийш нь хийчихсэн ч байж магадгүй, ой ухаан гэж ёстой байхгүй болжээ. Гэхдээ засаж болох явдал. Тэр томилолтыг чинь би ч үрэгдүүлж байсан удаатай, суугчид маань өөрснөө өвөртөлж яваад бас гээчихийг ч алийг тэр гэхэв. Мария Константиновна хуулбарыг нь дандаа өгдөг юм. Өө тийм, таныг паспорттойгоо сонгуулийн хэсэг дээр очоорой гэсэн, энүүхэнд холгүй ээ, сургууль дээр.

– Би сонгуулиас өмнө яваад өгвөл яахав?

– Тэд нар танд бүгдий нь тайлбарлаад өгнө, бүртгэлээс хассан тасалбар өгдөг юм.

Түр зуур ч болохноо сэтгэл амар байх санаатай, хаашаа ч очихгүй, хэнд ч учирлахгүй, хэнээс ч доромжлол хүлээхгүй гэсэн чинь ийм яланд унадаг байж. Болох гэж байгаа сонгуулийг зөвлөлтийн ардчиллын ялгуусан мандалт мэтээр сонин хэвлэлд бичиж байгаа.

“Коммунистууд болон нам бусчуудын эвслээс” “зөвлөлтийн ард түмний нэр төртэй хөвүүд, охид”-ыг депутатад нэр дэвшүүлж байгаа. Хамгийн түрүүчийн нэр дэвшигчээр нөхөр Сталиныг нэрлэж байна. Саша энэ бүхнийг өдөр болгон уншиж байгаа бөгөөд сонгууль өөрийнх нь хувьд төвөг удаж магадгүй гэсэн бодол хаа нэгтээ бүрэлздэг боловч түүнийг үлдэн хөөсөөр одоо ийм дээрээ тулдаг байна. Тэнэг толгой, тэгэхэд Глебийн үгэнд ороогүй, ороод хамт Калининаас хамт явсан бол паспортонд нь тэндхийн бүртгэл хэвээрээ байж байхгүй юу. Одоо сонгуулийн хэсэг дээр элдэв юм тодруулаад эхэлнэ, бүртгэлгүй хүнийг

гурван сар суулгасан гэж эзэгтэйг хөөдөх нь, дансанд оруулсан гэж Аялан тоглолтын товчоо, Мария Константиновнад ч бас хувь оногдоно. Яадаг хэрэг вэ? Верагийн нөхрийн ах дээр очдог ч юм уу, Уфад олон жил суусны хувьд ямар нэг юм зөвлөж магадгүй.

Хуучин оготор тэрлэгтэй, айдас хурсан харцтай эмэгтэй түүнийг угтав.

Саша өөрийгөө танилцуулаад,

– Вера Александровна миний тухай та нарт бичсэн, бас Сергей Петровичид утасдсан гэж нэмж хэлэв. Эмэгтэй толгой сэгсчин,

– Үгүй, үгүй чиш. Сергей Петрович байхгүй, удаан хугацаагаар явсан, хэзээ ирэхийг мэдэхгүй гэв.

Толгой л сэгсчээд байхаас, суу ч гэсэнгүй, Сашагийн араас хаалгаа бушуухан хаах л ганц хүсэлтэй байсан байх.

Саша буцлаа. Ял эдэлж байсан түүнийг хүлээн авахаасаа айсан байх.

Бүтэн сайнд Москва руу утасдсанд, ээж нь,

– Чи Верагийн өгсөн хаягаар очих хэрэггүй шүү, хадам ах нь эмнэлэгт удаан хугацаагаар хэвтсэн гэж хэлжээ.

Верагийн хамаатан баригдсан, тэгээд авгай нь тэгтлээ айж байсныг Саша ойлгов. Гурван хүүхдийн эцэг, жирийн инженер тэр хүнийг бас шоронд хийчихэж.

Энэ бүхэн бүтэн сайнд тодорхой болсон, харин тэр нэг өдрийн орой Саша,

– Чиний зөв болж таарлаа гэж Глебт хэлсэн аж.

– Юу болоов, ялдам минь?

Саша эзэгтэйтэй ярьсан зүйлээ хэлэв.

– Чи яг орооцолдож дээ, ялдам минь, башкируудын ярьдгаар, “ура” хашгарахын оронд “харуул!” гэж хашгарч алдаа хийсэн гээч л болж хэмээн Глеб инээмсэглэв.

– Маргааш Уфагаас явна аа, тэгэхгүй бол багалзуурдаад авна. Мэдээж, миний буруу, эзэгтэйг ч, Мария Константиновнаг ч, бас Семёнийг ч хөөдөж байна, гэхдээ өөр яахав ээ дээ?

– Чи тэднийг яаж хөөдлөө гэж? хэмээн Глеб түүн рүү доогтой харлаа.

– Би яваад өгнө, энэ явдлын балгийг эд нар л амсах болж байна.

– Бусдын төлөө л санаа зовоод байх шив. Хүн төрөлхтний төлөө, хэн нэгнийг хөөдчих вий гээд л... Хүн төрөлхтөн чамаас зөвөлгөө хүсэхгүй, өөрийнхөө талаар өөрөө санаа тавина.

– Чиний юун тухай яриад байгааг би ойлгохгүй байна.

– Тэрний чинь тухай л ярьж байна. “Эд нар амсах болж байна”. Тэд юу амсах юм бэ?! Нэг муу явуулын бүжигчин ирээ л биз, хэсэг тэнээ л биз, бүр бүртгүүлэлгүй л байж байгаад яваад өгөө л биз, юу юм бэ тэр чинь... Хийдгээ хийчихээд, баяртай гээд л алга болоо биз. Тийм хамхуул хэдэн арваараа байгаа, ялдам минь. Чиний хэргийг хэн мөрдөх юм бэ, хэнд чи хэрэгтэй юм бэ? Хүн гурван сар бүртгэлгүй суусан бол байрны захиргаа эндсэн байна. Мария Константиновна юу? Их л сайндаа Семёнд: “Та чинь яасан гоомой хүмүүсийг ажилд авдаг юм бэ!” гэнэ биз. Өөрөө ч бас хий гаргасан юм чинь. Тэгээд л гүйцээ. Явах юм бол, мэдээж, өөрөөсөө өөр хэнийг ч хөөдөхгүй. Шинэ газар очоод юу хийх болж байна? Охид чамд унаж үхдэг ч гэсэн, ажилд нэмэртэй хүүхэнтэй шууд таархгүй шүү дээ. Тийм шүү, ялдам минь, чамайг явлаа гээд эдэнд амсах балаг байхгүй. Харин үлдэх юм бол цаадуул чинь, Семён ч, манай ганган Маша Константиновна ч толгойгоо ажиллуулах ёстой болно: тэд өөрсдийнхөө алдааг засах хэрэгтэй болно, чамайг аргалах ёстой болно.

– Ингэж ч арай болохгүй ээ, өдөөн хатгасан амьсгаа ороод байна.

– За тэр дээ, энэ бол чиний муу ялзарсан сэхээтэн зан чинь, ялдам минь! Чи явж амжина, урьдаар бүх боломжоо үзээд алдах хэрэгтэй. Семёнд чи хэрэгтэй, чи бол Уфад алдартай хүн, Семён гэрээ хийх болоход цаадуул нь нөгөө Хөдөлмөрийн ордонд хичээл заадаг хар толгойтыг манайд ирүүлээрэй гэцгээж байгаа, чи ийм алдар цуутай болчихоод байгаа... Үнэнээ хэлэхэд, би чамайг ингэнэ чинээ санаагүй шүү! Семён чамайг явуулчихаад, өөрөө бүлэг дамжин гүйж байх хэрэг үү? Чи түүнийг гангарах гэсэндээ, буурь заах гэсэндээ таяг тулж явдаг гэж бодож байна уу? мань хүн хөл муу, анхны хичээл дээр нэг их мундаг амьтан харагдаж байгаа болохоос биш дараа нь хоёр хоног хэвтэж байгаа юм чинь. мань хүн өдөрт зургаан цаг зүтгэж чадах уу? Тэгээд ч чиний орны хүн алга. Тэгэхээр мань хүн чиний явдлыг зохицуулах ёстой. Мария Константиновнотой тохирчихно, чи бүү санаа зов! Тэр чинь Семёнтой хүлээстэй, хаашаа ч зайлахгүй, бас чадахгүй юм байхгүй. Саяхан нэг заяагүй юманд түр ч гэсэн бүртгэлтэй байр зохицуулж өгсөн, чамд бол ямар хамаа байна, гурван сарыг чинь хаагаад өгвөл болох нь тэр. Сэргийлэх тамгаа палийтал дарлаа, тэгээд л эрх чөлөө мандтугай. Семёнтой ярилц, хамаг юмаа ний нуугүй хэл, цаадах чинь овжин эр, яг ёсоор нь болгоно гэж мэд.

Бүх юм Глебийн тооцоолсноор болов. Семён Григорьевич Сашагийн паспортыг аваад, маргааш нь хоёр томилолттой буцааж өгсний нэг хуулбарыг нь байрны эзэгтэйд, нөгөөг нь “Түр бүртгэхийг хүсье” гэсэн нэмэлттэй, шинэ хаяг бүхий газарт зориулсан аж. Саша явж тэр байрыг үзвэл Уфа хотын захын нэг муу өгөр байшин аж, ногооных нь хашаа намар цагийн туулахын аргагүй шавар. Байрны эзэгтэй гэж явигнасан эмгэн ор гэх модон наартай, шүүгээний оронд хаалгандаа хадаас шаасан хариугүй умгар өрөөг зааж өгөөд, паспорт, томилолт хоёроос гадна нэг сарын хөлс урьдчилан авав. Энэ хөөрхий оромж хотын төвийн өрөөнөөс хоёр дахин илүү үнэтэй буй нь бүртгэлийн үнэ цэнэ аж.

Саша энэ оромжны сүгэнд суух, хичээлийн дараа шөнө болгон ийшээ санжганаж явах бодолгүй байв. Хотод суух бүртгэлтэй юм чинь одоо хаа хүссэн газраа амьдарч болно. Хадаасанд хуучин костюм, өвөл хэрэг болохгүй цув хоёроо өлгөж, нааран доогуур муудсан шаахайгаа шургуулж, сохор мэт цонхны хавьд байсан исар дээр шүднийхээ сойзыг тавьж,

Өнгөнөөс нь харвал орон сууцны янз оруулав. Сонгуулийн хэсэг дээр очиж, комиссын гишүүдэд өөрийгөө харууллаа. Комисс гэх гурван хүн паспортыг нь шалгаж, нэрсийн жагсаалтад оруулаад, санал өгөх урилга гардуулах зуур ямар ч шаардлагагүй байхад түүнийг өлөн нүдээр өрөмдөцгөөн, ярихдаа албархацгааж байжээ.

Ингэтэл гучин гурван оны эхээр Москвад тэдний байшингийнхан яаж паспорт авч байсан нь санаанд нь ороод ирэв... Оршин суугч болгон бөгөлсөн анкетаа барьж ороод, төрсний гэрчилгээ, ажлын газрын магадлагаа хоёрын хамт ширээн дээр тавина. Сэргийлэхийн түшмэл тэр бичиг цаасыг шалгаад, ямар нэг ойлгомжгүй юм байвал, буцааж өгч шинийг авчрахыг шаардана. Баримт бичиг ёсоор байвал ширээнийхээ шургуулгыг татаж, тэнд байгаа жагсаалттай тулгаад, анкетан дээр цохолт хийн паспортын хүүхэнд өгнө.

Энэ журам яагаад хэн нэгнийг түгшээж, санааг нь зовоож байгааг Саша тэгэхэд ойлгохгүй байсан: энд гэмт хэрэгтэн байхгүй, насаараа энэ байшинд аж төрсөн, Саша аль хүүхэд ахуйгаасаа олон хүнийг танина. Өөрийнх нь өмнө дугаарт байсан Гурцевийг Саша бас хар багаасаа мэднэ, ноднин өөд болсон нэртэй бүжигчний нөхөр, эелдэг сэхээтэн хүн. Гурцев баримт бичгээ гаргаж тавьсанд сэргийлэхийн түшмэл тэдгээрийг гүйлгэж үзсэнээ, ширээн доторхи нэрсээ зэрвэс хараад Гурцевийн баримт бичгийг тусгай хавтсанд хийчихэв.

– Маргааш арван нэгэн цагт сэргийлэхийн наймдугаар анги дээр очоорой.

– Та болгооно уу... хэмээн Гурцев эхлэв.

– Иргэн гуай, би танд бүгдий нь тайлбарласан. Дараагийнх нь!

– Гэхдээ би юу... мэдмээр байна...

– Тэндээс бүх юмыг мэдэж авах болно. Дараагийнх нь!

Ээжийнх нь дараа ярьснаар бол Гурцевт паспорт олгоогүй, Москвагаас явахыг тушаасан аж: түүний эцэг хувьсгалаас өмнө үйлдвэрийн эзэн байсан юмсанж. Тэдний байшингийн өөр хэдэн айлд паспорт олгоогүй. Нөгөө хоёр эмгэнд ч бас адил. “Паспортгүйчүүд” зуун нэг дэх километр рүү явцгаасан гэгцгээж байсан.

Тэгэхэд мань хүн яагаад дуугүй байсан бэ, яагаад эгдүүцээгүй вэ? Өөрт нь хамаатай болоод ирэхээр бодлогоширч байх юм.

Саша Глебийнд суудаг болов. Эзэгтэйд нь гучин рубль нэмж өгч, эвхдэг ор тавиад болох нь тэр. Өөрийнхөө оромжинд Саша голдуу бүтэн сайны өглөөгүүр долоо хоногт нэг удаа очно, арван нэгдүгээр сарын 7-нд баярын бэлэг гэж бялуутай очсонд эмгэн “Амттай юманд дуртай” хэмээн их баярлажээ. Суугчид нь ирж хонодоггүйд дассан болохоор яагаад ирж хонохгүй байгааг асуухгүй, харин арван хоёрдугаар сар ойртох тусам ирэх болгонд нь ирж саналаа өгөхийг сануулан, тэгэхгүй бол би муугаа үзнэ, өөрт нь энэ тухайд хатуу анхааруулсан, эртхэн ирвэл зүгээр, өдрийн арван хоёроос хойш айлын байраар явж, ирээгүй хүмүүсийг цуглуулна гэж байна лээ гэхчлэн үглэнэ.

Глеб сонгуулийн тухайд бас урьдчилан анхааруулжээ:

– Хүний нэр дарна гэж хийрхэв дээ, саналын хуудас бүгд тэмдэгтэй, шууд л танина гэж мэдээрэй.

Саша цорын ганц нэр дэвшигчийн нэрийг, мэдээж, дарсангүй, тэр нэрийг тогтоосон ч үгүй, танхимын нөгөө буланд байгаа бүхээгт ч орсонгүй, орох юм бол дарах гэж байна гэж бодоцгооно. Булан болгонд зогсож байгаа “олон нийтийн төлөөлөгчдийн” урдуур явж, хайрцаг руу очоод саналын хуудсаа хийжээ.

Бүх хүн яг ингэнэ. “Коммунистууд болон нам бусчуудын эвслийн” төлөө сонгогчдын 98,6 хувь нь саналаа өгсөнд гайхах юм ердөө байхгүй. Сонгуулийн өмнөх цуглаан дээр Сталины: “Ийм жинхэнэ чөлөөт, жинхэнэ ардчилсан сонгууль дэлхий дээр урьд өмнө хэзээ ч байгаагүй, хэзээ ч! Түүх ийм жишээг мэдэхгүй...” хэмээсэн үг ч гайхал төрүүлээгүй. Харин эсрэг санал өгсөн бараг бүтэн хагас хувь хаанаас гарч ирсэн нь гайхал төрүүлсэн болой.

Шпигельглас явахынхаа өмнө “Макс”, бас “Тюльпан” гэдэг нууц нэртэй Марк Григорьевич Зборовский гэгч агенттай барьдаг холбоогоо Шарокт шилжүүлжээ. Шпигельглас яарч байсан боловч энэ агент үнэхээр чухал этгээд учир энэхүү холбоог өөрөө байлцан тогтоох шаардлагатай гэж үзсэн аж. Зборовский Парист “Сөрөг хүчний сэтгүүл”-ийг гаргахын хамт IV Интернационалыг үүсгэн байгуулахаар ажиллаж байгаа Троцкийн хүү Лев Седовын хувийн нарийн бичгийн дарга, итгэмжит хүн бөгөөд хамгийн дотнын анд нь аж.

Шпигельглас аль хэдийнэс Троцкийг намнах зорилготой байгаад Шарок өчүүхэн ч эс эргэлзэнэ. Шпигельглас тухайн үедээ энэ хэрэгтээ Скоблин, түүний Болгарт байгаа дотнын анд генерал Туркул хоёрыг тулгуур болгож байж. Троцкийг цагаан гвардийнхан алсан байвал иргэний дайнд ялагдсаны өсийг авсан үйлдэл болж харагдах учиртай. Троцкийг Туркээс Европ руу шилжин нүүхэд Миллер, Драгомилов нарын хүмүүс нөгөө явдалд оролцсон. Гэвч тэр нь нурсан. Бүтээгүй.

Троцкийн 1937 оны нэгдүгээр сараас суурьшсан Мексикт бол оросын цагаантан цагаачид байхгүй. Марк Зборовский л хүүгээр нь дамжин эцгийнх нь ойр орчин руу нэвтэрч чадах цорын ганц хүн. Одоохондоо тэр бол мэдээллийн үнэтэй эх сурвалж. Лев Седов түүнд эцэгтэйгээ харилцах хувийн захидлаасаа авахуулаад бүх юмаа итгэн даатгадаг бөгөөд эцэг, хүү хоёр захиандаа Зборовскийг Этьен гэнэ. Хэр зэрэг итгэдгийг Лев Седовын эцэгтээ: “Надтай маш нягт холбоотой, аль ч талаасаа туйлаас итгэвэл зохих Этьен миний эзгүйд намайг орлож байх болно” гэж бичсэн захидал харуулна. Энэ захидлын хуулбарыг, эцэг хүү хоёрын харилцсан аливаа бусад захидлын нэгэн адил Зборовский Шарокт өгсөн ажээ. Тийнхүү, Троцкий болон түүний талынхны алхам бүрийг Москвад мэдэж байв. Нууц мэдээнд Лев Седовыг “хөвүүн”, Троцкийг “өвгөн” гэнэ.

Үг цөөтэй, удаан хөдөлгөөнтэй, цайлган тунгалаг харцтай энэ Зборовский гэдэг боловсон еврей Шарокт таалагджээ. тэрээр Украинд, Умани хотод 1908 онд төрж, хожим Польшид аьдарч байсан, Польшийн коммунист намын гишүүн байсан, тэндхийн шоронд нэг жил суусан, авгайн хамт Берлин явж, дараа нь Парист ирсэн, 1933 онд түүнийг урвуулан элсүүлжээ. Зөвлөлтөд эгч, хоёр дүү нь үлджээ.

Зборовский дараагийнхаа уулзалтаар троцкист IV Интернационалын их хурлын бэлтгэлийн тухай материалыг, ирэх ёстой төлөөлөгчдийн нэр, хаягийн хамт Шарокт өгчээ. Мөн эцэг, хүү хоёрын сүүлийн үед харилцан бичсэн захидлын хуулбарыг гардуулжээ. Зборовский анхны уулзалтынх шигээ хөдөлгөөн тайван, хараа цайлган тунгалаг байв. Энэ хүн Третьяков шиг олон юм бурахгүй, Скоблин шиг дээрэлхүү загнахгүй, өөртөө эрэмшсэн зангүй, Шарок польшуудын тийм занд дургүй, ер нь өнгөн дээрээ зөөлхөн, дотроо бол үнэ цэнээ мэддэг чанга байрын хүний сэтгэгдэл төрүүлнэ. Илүү дутуу юм ярихгүй. Седовын албан бус эхнэр Жанна Мартины тухай ярихдаа, тэдний гэр бүлийн харилцаа бас төвөгтэй хэвээр байгаа, тэр хөөрүү хүүхэн хуучин нөхөр Раймон Молинье ч, шинэ нөхөр Лев Седовыг ч эрхэндээ байлгах санаатай байдаг хэмээжээ. Гэтэл Молинье нь улс төрийн үйл ажиллагаанаас хөндийрсөн, Седов, Жанна хоёрыг холбож байдаг ганц юм нь түүний зээ дүү Сева Волковыг хүмүүжүүлэх асуудал гэнэ. Тэр хүү Зинаида дүүгийнх нь, түүнийг амиа хоролсны дараа

урчилж авсан юм байж. Зборовский энэ тухай зарим талаар Седовыг өрөвдөж байгаа бололтой, даруухан ярьжээ.

Товчдоо, Седов яагаад Зборовскийд итгэж байгааг Шарок ойлгож байв. Тийм хүнд итгэхгүй байхад хэцүү. Мэдээж, Зборовский итгэлийнх нь хариуд урван тэрсэлж, урван тэрсэлснийхээ төлөө мөнгө авч байгааг мэдэхгүй бол л тэр шүү дээ. Шарок зохих байгууллагад тав дахь жилээ ажиллаж буйн хувьд юуг ч гайхахаа больжээ. Баатар ч гэж байхгүй, журмын нөхөр ч гэж байхгүй, гэгээнтэн ч гэж байхгүй. Хэнийг ч худалдаж авч, зарж, урвуулж, нугалж, хугалж, айлгаж болно. Цэргээс авахуулаад маршалыг хүртэл, жирийн ажилчнаас авахуулаад сайдыг хүртэл, хэнийг ч. Жишээ нь, Шарок Парисын нэг сониноос, нөхөр Сталин Иосиф Жугашвили нэртэй ахуйдаа хаант засгийн хамгаалалтын албаны “Фикус” гэдэг хочтой хөлсний мэдээлэгч байсан тухай хуучин жандармын хурандаагийн бичсэн өгүүллийг уншсан, тэнд бүр Жугашвилийн цагдаа нартай хамтарч ажиллаж байсан баримтуудыг оруулсан байж. Бас өдөөн хатгагчдыг илрүүлдгээрээ алдаршсан Бурцев большевикуудын Төв Хороонд хаант засгийн хамгаалалтын албаны хоёр ажилтан байсныг тухайн үедээ нотолж байсан; Малиновский гэдэг нэгийг нь Бурцев илчилсэн, нөгөөг нь нэрлэж чадаагүй, гэхдээ бий гэж зүтгээд байсан. Одоо Бурцевын тэр нотломжийг жандармын хурандаа баталж, өдөөн хатгагчийг Сталин гээд нэрэлчихлээ.

Шарок үүнд итгэж байсан уу? Яагаад итгэхгүй сэн билээ? мань хүн өөрөө зөвлөлтийн хамгаалалтын албанд алба хааж байгаа юм чинь Сталин хаант засгийнхад яагаад алба хааж болохгүй байх билээ. Тагнуул, мэдээлэгч нар бол байгаа зүйл, байсаар ирсэн, хойшид ч мянга мянган жилээр байх л болно. Тийм ажил хийхгүй гэх баталгаа хорвоо дээр хэнд ч байхгүй. Гэхдээ Шарок ийм өгүүллийн тухай хэнтэй ч хэлэлцэж байгаагүй – уншаагүй, үзээгүй, мэдэхгүй, сураг ч сонсоогүй гэсхийнэ. Энэ тухай дурссан төдийгөөр толгойгоо авахуулж мэднэ. тэрээр бүх юман дээр болгоомж сэрэмжийг хичээнэ. “Сөрөг хүчний сэтгүүл”-ийн ээлжит дугаарыг Шпигельглас нэг удаа өгөхдөө: “Энэ бөөлжсийг надад унших ч хүсэл алга” гэж хэлсэн. Шпигельглас: “Үгүй, юу гэсэн үг вэ, дайснаа мэдэж байх хэрэгтэй” гэж хариулсан. Иймэрхүү эрэгцүүлээд байвал ч Шпигельглас ч сайнаа үзэхгүй дээ. Бас Троцкий ч сайнаа үзэхгүй. Хүүгийнх нь хамгийн сайн найз манай агент. Эцэг нь ч, хүү нь ч түүнд итгэж, өөрсдөд нь чин үнэнч хүн гэж үзнэ, орос хэлний тэр хоёр үг нэг үндэстэйг мартаж л дээ. Хэнд ч итгэж болохгүй. Троцкий үүнийг ойлгохгүй байна, тийм учраас балрана. Харин нөхөр Сталин бол ойлгож байна, хэнд ч итгэхгүй байна, орчин тойрныхныгоо хуу хядаж байна, энэ махны машинд урван тэрслэгчид тээрэмдүүлж байгаа, гэхдээ чин үнэнчээр зүтгэдэг хүмүүс ч тээрэмдүүлж байгаа нь бас үнэн.

Зборовский нэгдүгээр сарын сүүлчээр Седовын бие барагтай байна, гэдэс нь өвдөөд байна гэнэ гэж Шарокт мэдээлэв. Мэдээж, хэний ч гэдэс өвдөж болно, гэхдээ Зборовский энэ тухай хэлэхдээ харцанд нь нэг юм зурсхийж, дуу нь ч арай л өвөрмөц өнгөтэй байж. Энэ бол онцгой чухал мэдээ гэдгийг Шарок ойлгов. Ийм нөхцөл байдлыг тухайлан урьдаас ярилцсан тул тэрээр Москва руу, Шпигельглас нууц мэдээ илгээлээ. Цаадах нь “хөвүүний” биеийн байдлын тухай өдөр болгон илтгэж байхыг тушаагаад, “Алексей” ердөө маргааш Парист очно, түүнийг “Макс”-тай уулзуулахаар зохион байгуул, өөрөө тэр уулзалтад оролцох хэрэггүй гэж даалгажээ.

Шарок Москвад байхдаа Лубянкад “Алексей”-г нэг удаа зэрвэсхэн харсан. Боксчин байсан, харахад шалихгүй энэ хүн франц хэлийг тэгтлээ сайн эзэмшсэнийг тэгэхэд гайхсан билээ. “Алексей” Яков Исакович Серебрянскийн удирддаг бүлэгт байдгийг Шарок мэдсэний дараа түүний яагаад тийм сайн эзэмшсэнийг ойлгожээ.

Шарок тэр үеийнхээ даргын даалгаврыг биелүүлэх ажлаар Гоголийн цэцэрлэгт гудамны нэг өргөөнд байх Серебрянскийн гэрт нэг удаа очиж байсан, Полина Натановна гэдэг авгайтай нь хүртэл танилцсан юм байж. Мундаг авгай. Ухаалаг нүдэй. Шарок “намтартай эгч гуай” хэмээн хүндлэн бодсон. тэрээр төрсөн сэтгэгдлээ тэднийхээс гарсан хойноо эрэгцүүлэхдээ Серебрянский бол Ромын язгууртантай төстэй хүн байна даа гэж шийджээ. Дунд зэргийн чацтай, янхирдуу царайтай бахим эр. Тэр хүн хуучин эсер байсан, тэдний байгууллагад тусгай даалгаврын, өөрөөр хэлбэл, эсрэг этгээдүүдийг хулгайлах, устгах ажиллагаа явуулдаг бүлгийг удирддаг гэдгийг Шарок тээр хожуу олж мэджээ. Энэ бүлгийн ажилтан нарыг чекистүүд нүднээс далд “Яшагийн хөвүүд” гэнэ. “Алексей” энэ бүлгийн ажилтан учраас түүний ирж байгаа зорилгыг тааж цөхөх юм байсангүй.

“Алексей” Зборовскийтэй уулзсаныхаа дараа дорхноо алга болчихож. Зборовский Шароктой холбоо барьсаар байгаа бөгөөд Седовын бие бүр муудаад, Rue Narcisse Dias гудамжны эмнэлэгт Мартен гэдэг ноёнтны (Жаннагийн овгоор) нэрээр хэвтсэнийг төдөлгүй мэдэгдэв. Түүн дээр зөвхөн Жанна, Зборовский хоёр л орох эрхтэй. Одоо Зборовскийгоос өдөр бүр мэдээ ирдэг боллоо. Шарок тэдгээрийг Москвад дамжуулна. Хоёрдугаар сарын найманд Седовын мухар олгойг авч, тэр мэс ажилбар амжилттай болжээ. Еснөөс арван гурван хүртэл өвчтөн өрөөн дотуураа яваад, биеийн байдал сайн байж. Арван дөрвөнд шинэ мэдээ ирэв: өчигдөр үдшээс Седовт гэнэтхэн хий юм харагдаад эхэллээ. тэрээр ямар нэгэн юм оросоор хашгачин, эмнэлэг дундуур гүйж байгаад захирлын өрөөний буйдан дээр ойчоод өгч. түүнд дахин цус юүлсэн боловч амийг нь авч чадсангүй. Хоёрдугаар сарын арван зургаанд Седов ухаангүй байж байгаад нас баржээ. Задлангаар юу ч илэрсэнгүй. Тэртэй тэргүй юу ч илрэх ёсгүй байж. “Алексей”-н дамжуулсан эмийн талаар франц эмч нарт мэдлэг байсангүй, зөвхөн арав дахь өдрөө үхэлд хүргэдэг үйлчилгээтэй эд. Седовыг эмнэлэгт хэвтүүлэхийн өмнө тэр нунтгийг хоолонд нь хольсон юмсанж.

Хоолой нь сэрвэгнээд, салхи авсан учир эмч нар гэртээ байзнахыг зөвлөснөөр Сталин Кремль рүү явсангүй.

Бүрхэг өдөр. түүний тушаасан ёсоор сэхээвчний цасыг арилгахгүй байгаа билээ. Тэр цасан дээр мөр алга, хэн ч хавьтаагүй байх нь. Тэгээд хөндөөгүй цагаан цас хэзээ хэзээнийх шигээ сэтгэл тайвшруулна. Цас моддын дээр нэвсийж, харуулын шовгорын дээвэр дээр хөвсийн харагдана. Дээврийн цасыг түүнийг Кремль рүү явсан цагт л арилгана, харин түүнийг зуслан дээр байгаа үед дээвэр гарч цас хүрздэхийг зөвшөөрөхгүй: толгой дээр нь юм хяхтнах, дээд талд нь хөлийн чимээ гарах энэ тэрд дургүй. Тэр ч бүү хэл, хашаа хороонд юм хийж түүнийг сэрээхээс айгаад, хашааны хаалганаас байшин хүртэлх замын цасыг ч арилгахгүй.

Өрөө нь бүрэнхийдүү ч Сталин гэрлээ асаасангүй, өвлийн ийм бүрхэг өдөр гэрт нь нам гүм, амар жимэр байхад дуртай, гэрэл асаахаар тэр тухлаг байдал нь арилчихна гэж үзнэ. Нүүр гараа угаалаа. Сахлаа хуссангүй, өнөөдөр харах хүн байхгүй юм чинь.

Валечка царан дээр өглөөний унд авчирлаа.

– Иосиф Виссарионович, та ямар байна? Бие нь сайн уу?

– Сайн байна. Номын санд орно оо.

Үйлчлэгч түүн рүү эмээхийн харав.

– Юу гэж хараав, танихгүй байна уу?

– Иосиф Виссарионович, та чинь гэртээ байя гээ биз дээ. Эмч нар ч бас...

– Номын санд очихыг эмч нар зөвшөөрсөн гэж Сталин үгийг нь тасдав.

– Тэгвэл ч яахав, маш ойлгомжтой.

Тэр “яахав”, “маш ойлгомжтой” гэдэг нь дараахь байдлаар илэрчээ: Сталиныг эсгий гуталтай, үстэй дээлтэй, хулгавчилдаг малгайтай гэрээсээ гарахад, байшингаас номын сан хүрэх замын цасыг цэвэрлэчихсэн, газар давхар бүхий номын сангийн модон байшингийн довжоог шүүрдчихсэн байв. Номын сан нь ч салхи оруулчихсан, дулаахан сайхан байв. Хэдийдээ амжуулчихаа юм бол?

Олон ном тавиур дээр цагаан толгойн дарааллаар, салбар салбараар зөв байрласан учир тэрээр хэрэгтэй номоо амархан олно, хайж цаг үрэх дургүй. Карл Маркс ном ухахыг дуртай ажил нь гэж ярьдаг байсан. Маркс улс удирдаж байгаагүй болохоор ном ухаж байх цагтай байж. Ленин, Улсын нийтийн номын сан ном гадагш нь гаргадаггүй учир, ном хэрэг болох бүрийд нэг дэх өдөр буцааж өгөхөөр бүтэн сайнд өгөөч гэж гуйдаг асан. Засгийн газрын тэргүүний хувьд хууль яаж биелүүлэх жишээ үзүүлж байгаа нь тэр үү? Үгүй шүү. Зүгээр л номын сангийн журмыг ёсчлон дагах боловсон заншил. Ленин, үнэн чанартаа бол, номын

хүн, үүнээс томоохон алдаанууд уршиглаж байсан. Харин түүний хувьд ном бол зөвхөн ажлын нэг хэрэгсэл, түүнээс цаашгүй.

Ширээн дээр “Сталины хүүхэд ахуйн тухай өгүүллэгүүд” байна. Өөрт нь зориулж нэг хувь хэвлээд одоо нийт хувиа хэвлэхээр түүний зөвшөөрлийг хүлээж байгаа аж. тэрээр зөвшөөрөл өгөхгүй. Энэ бол муу ном. Хэрэггүй ном. Сайхан сэтгэлтэй эцэг эх, эв найртай гэр бүл гээд бүх юмыг сайхнаар будаж, зулгуйдсан байна. Хар худалчууд! “Нутгийнхан” гойд эгдүү хүргэж байна, зохиогчид нь сав л хийвэл тэднийг өмнөө барьсан байна. Муусайн өлөгчингийн гөлөгнүүд яаж хичээж байна гээч! “Багын найз нар” болох юм гэнэ, ер тийм юм байгаагүй. тэрээр өөрийг нь ад үздэг, эсвэл тоодоггүй байсан энэ шижээргүй, танхай бандь нарыг санах юм алга. Тэд одоо өчүүхэн биеэ харуулах гэж, түүхэнд үлдэх гэж алтан гургалдайчлан донгодож байна.

Орос эмэгтэй бичсэн хэрнээ энэ ном нэвт шувт гүржчилэгджээ. Ая тал засах гэж л дээ, тэнэг эм! Туж гүрж нэрс, зүгээр ч үгүй хүүхдийн нэрс: Зурико, Бесико, Темрико, Отарико, Гоги... Орос хүүхдүүд Сосо, Сосико... гээд л дооглоно доо.

Володя Ульянов гэдэг нэг хүүхэд нэгэнт байж байгаа. Цаанаа л нэг орос агь оргисон, буржгар, хөөрхөн цагаан хүү, тэмдэг болгон дээр, саравчтай малгай болгон дээр зураастай байгаа, мэдэж байгаа биз, орос язгууртны хөөрхөн хөвүүн. Бас нэг хүүхдийн хэрэг юу байна?! Нэмэрт нь Сосико гэдэг хачин, хөгийн нэртэй шүү?! Зөвлөлтийн хүүхдийн хувьд мань ХҮН тэдний үе тэнгийнхэн бус, френчтэй, савхин гуталтай, бүхнийг чадагч жолоодогч нөхөр Сталин байх ёстой, хүүхдүүд цэргийн дүрэмт хувцсыг биширдэг юм чинь. Ленин бол хаа нэгтээ их алсад байгаа, харин ӨӨРӨӨ бол амьд сэрүүн хүн. Зөвлөлтийн хүүхдийн хувьд амьд хүн байх ёстой, амьд эцэг, амьд Бурхан байх ёстой. Үхсэн Иисус нялх хүүхэд байж болно. Иисус, Ленин хоёр өөрсдийн түүхэн үйл хэргээ бүтээчихсэн, тэгэхээр одоо хайр булаасан нялхас байж болно. Харин мань ХҮН бол үгүй, тийм байж болохгүй.

Ухаж төнхөөд л байна! Осетины эрдэмтэн гэх нэг годил нөхөр Сталин Осетины Зугата омгийн хүн гэх маягийн судалгаа бичсэн. Осетид Зугата гэдэг тосгон бий, тэндхийн гаралтай бүхэн Зугата. Умард хэсэгт нь загалмайлсанд оросын “ев”, “ов” гэдэг төгсгөл нэмээд Зугаев, Зугатов болсон, өмнөд хэсэгт нь гүржийн ламтан “зе” буюу “швили” залгасан аж. Тийнхүү түүний өвөг дээдэс эхлээд Зугашвили, дараа нь Жугашвили болцгоосон гэнэ. Одоо аль аль нь түүнийг өөрийн болгох гээд байна: осетинчууд осетин, гүржүүд гүрж.

Гитлер өөрийн өвөг дээдсийн талаар бичихийг хориглодог. Зөв хийж байна! Гитлерийн эцэг, тариачин эмэгтэй Шикльгруберийн бутач хүү Алоис эхийнхээ овгоор овоглодог байснаа хожим гэнэт түүний эцэг Гитлер гарч ирж, мань Алоис Гитлер гэгдэх болж, хүү Адольф нь ч бас Гитлер болсон гэж байгаа. Гитлер зүйтэй шийдсэн байгаа юм: германы ард түмэнд энэ бүхнийг мэдэх ямар хэрэг байна? дэмий буруулах гэж тэгэх үү, “Хайль, Шикльгрубер!” гэвэл яасхийж сонсдох бол хэмээн доог тохуу хийцгээж байг гэж тэгэх үү?

Элдэв солиотой юмнууд Лениний намтрыг онгичиж байна: Лениний өвөг дээдэс эцгийнхээ талаас орос, халимаг, эхийнхээ талаас швед, еврей гэнэ. Зөвлөлтийн ард түмэнд энэ ямар хэрэгтэй юм бэ? Гитлер яс үндэс цэвэр байлгахыг шаарддаг, ӨӨРӨӨ бол тэгж шаарддаггүй. түүний хүүхдийн эцэг нь гүрж, эх нь орос, бас ч гэж жаахан герман хольцтой. Тэглээ гээд юу

гэж?! Оросын ард түмэн бол славянчуудын угрофинн, түрк, монголтой холилдсон хольц. ЗСБНХУ-ын дотор холимог гэр бүлийг сайшаах хэрэгтэй, тэд бол зөвлөлтийн нэгдмэл ард түмнийг бүрдүүлж байна. Харин гадаадынхантай гэр бүл болохыг тас хориглож байх хэрэгтэй. Тийм гэр бүл тагнуул хийх, урван тэрслэх энэ тэрд л тус дөхөм үзүүлнэ. Гадаадын хунтайж нартай гэр бүл болж байгаад Романовынхан юу болсон билээ? Сүүлчийн хаан Хоёрдугаар Николай үнэн хэрэгтээ герман болж таарсан, түүний бүх өвөг дээдэс герман хүүхэнтэй байсан, тийн Хоёрдугаар Николайд орос цус юу ч үлдээгүй. Тэгээд л ард түмэн түүнийг сэнтийнээс нь авч хаясан: хаан нь герман, хатан нь герман, тэр яаж өөрийнхөө германуудын эсрэг байлдах билээ?

мань хүн үе дамжсан хааны удмынх биш, ер нь ч түүнд элдэв удам хэрэггүй. Ээж нь гүрж, эцэг нь гүрж гэсэн данстай, тэгэхээр мань хүн ч гарлаараа гүрж, үнэн хэрэгтээ бол орос, юуны өмнө оросын ард түмэнд харьяална, түүний бүх амьдрал, үйл ажиллагаа оросын ард түмэнтэй холбоотой. Гэтэл энэ муу эрдэмтэн гэх годил Горийн цогчин дуганын 1878 онд загалмайлсан хүүхдийн дансыг ухчихсан байгаа юм. Тэнд, Горийн тариачин Виссарион Иванович Жугашвили, түүний авааль гэргий Екатерина Габриеловна нарын дундаас арван хоёрдугаар сарын 6-нд хүү Иосиф төрсөн гэх ухааны юм бичээтэй байгаа гэнэ. Шинэ хүнийг хамба Хаханов, хиа лам Квиникизе нар загалмайлсан. Арван хоёрдугаар сарын 17-нд ерөөлийн адис хүртсэн гэнэ. Тэгвэл өөрөө нэг нас дарсан болох нь уу? Яах гэж? түүний нэрийг сэвтүүлж чадахгүй.

түүний жолоодогчийнхоо хувьд, удирдагчийнхаа хувьд хувьсгалд, иргэний дайнд, социалист бүтээн байгуулалтад хамаатай үүргийн тухай судалгааг — ийм буурьтай судалгааг сайшаан дэмжих ёстой, харин түүний хувийн намтрыг ухаж төнхөхийг үүрд бүрмөсөн зогсоовол таарна.

Сталин нэг цаасан дээр хөх будгийн харандаагаар ингэж бичив:

БХЛКЗЭ-ийн ТХ- ны дэргэдэх Детгиз-д

Би “Сталины хүүхэд ахуйн тухай өүүллэгүүд”-ийг шууд эсэргүүцэж байна.

Энэ бяцхан номонд өч төчнөөн ташаа зүйл, гуйвуулга, хэтрүүлэг, худлаа магтаал оржээ. Үлгэр домгийн донтнууд, хий бурагсад (“чин санаатай” хий бурагсад байж магадгүй), бялдуучид зохиогчийг төөрөгдүүлжээ. Зохиогчийг өрөвдөж байна, гэхдээ баримт бол баримтаараа л байж байна.

Гэхдээ гол юм бол энэ биш. Гол юм нь энэ бяцхан ном зөвлөлтийн хүүхэд багачуудын (ер нь хүмүүсийн) ухамсарт жолоодогч нарыг, алдаж энддэггүй баатруудыг тахин шүтэх үзлийг шингээх хандлагатай байгаад оршино. Энэ бол аюултай, хөнөөлтэй. “Баатрууд” ба “бөөгнөсөн хүмүүс”-ийн тухай онол бол большевик онол биш эсерч онол. баатрууд ард түмнийг бүтээдэг, тэд бөөгнөсөн хүмүүсийг хувиргаж ард түмэн болгодог гэж эсерчүүд хэлдэг. Ард түмэн баатрыг бүтээдэг гэж большевикууд эсерчүүдэд хариулдаг. Энэ ном эсерчүүдийн морийг эмээлж өгч байна. Аливаа ийм номонцор эсерчүүдийн морийг эмээлж өгнө. Манай нийтийн большевик үйл хэрэгт хор хүргэнэ. Энэ номонцорыг шатаахыг зөвлөж байна.

1938 оны хоёрдугаар сарын 16 И.Сталин

тэрээр нэг хавтсыг хажуу тийш нь тавьж, өөр нэгийг авлаа. Троцкийн тухай, түүний IV Интернационалын тухай тагнуулын мэдээнүүд болон “Сөрөг хүчний сэтгүүл”-ийн дугааруудыг тэрээр өдөр бүрий хардаг юм. “Сталинизм, фашизм хоёр бол тэгш хэмийн үзэгдэл юм. Энэ хоёр үзэл олон шинж чанараараа нэг нь нөгөөгөө нүгэлтэй адилхан санагдуулна...” Троцкист бантагнуулсан донгосоон! Большевизм, нацизм хоёр өрнөдийн хөрөнгөтний ардчиллыг, юуны өмнө ихэмсэг Английг ад үздэгээрээ л төстэй. Гитлер тэр хоёр нийтлэг дайсантай, энэ дайсан нь тэднийг нэгэн цагт холбох болно. Харин одоохондоо бол мань ХҮН өрнөдийн ардчилалтай өөрийнхөөрөө тоглож, тэднийг Гитлерээр айлгаж байгаа бол, Гитлер тэдэнтэй өөрийнхөөрөө тоглож, тэднийг Сталинаар айлгаж байна. Гэхдээ ард нь Англи, Франц хоёр байж байхад ЗСБНХУ-ын эсрэг дайтаж, тийм дайнд өөрийгөө тамирдуулна гэж юу байхав — Гитлер тийм юм хийхгүй. Троцкий үүнийг гойд сайн ойлгож байгаа учраас түүнийг Гитлертэй холбоо тогтооно гэж урьдаас хэлж, зөнч мэргэн болж таарах санаатай, ер мөчөөгөө тавихгүй байна. “Сталин большевик намыг устгаж байна... Сталин түүхэнд Каинчуудаас хамгийн жигшүүртэйгээр ад үзэгдэгчийн нэрээр орно... түүний өөртөө барьсан хөшөө дурсгалыг устгана, эсвэл музейд авч, захиргаадалтын аюумшигт үзмэрийн танхимд байрлуулах болно. Тэгээд ялгуусан ажилчин анги сталинч хорсол хийгээд бузар үйлийн золгүй золиос бологчдын хөшөөг чөлөөлөгдсөн Зөвлөлт Холбоот Улсын хот суурины талбайд босгоно... Сталинзмыг үүрд няц дарж, бут ниргэж, доромжлолоор булна...”

түүнийг няц дарж, бут ниргэх санаатай гэнэ! Новшийн шидэл! Хэн нь хэнийгээ няц дарахаа харна аа, гайгүй! Слуцкий, Шпигельглас хоёр чадахгүй бол тэрээр намын даалгаврыг биелүүлж чадах өөр хүмүүсийг олно. Эдний муу гэр бүлийг язгуураар нь тас цавчих ёстой, нэг ч хүн үлдэх ёсгүй.

Сталин тэр хавтсан дотроосоо Троцкийн гэр бүлийнхний нэрсийг гаргаж ирэв. Хэддэх ч удаагаа юм, дахиад уншив:

Борис Александрович Бронштейн, Троцкийн ач дүү — 37 оны аравдугаар сард Курскийн шоронд буудуулж алуулсан.

Ольга Давидовна, Троцкийн дүү — арван жилийн хорих ял авсан.

Александра Львовна Сокольская, анхны эхнэр — хорих ангид үхсэн.

Нина Львовна, Троцкийн анхны авгайн том охин — 1928 онд сүрьеэгээр үхсэн.

түүний нөхөр, Невельсон, 1937 онд буудуулж алуулсан.

Тэдний охин, Валя, 1925 онд төрсөн, ДЯАК-ын хүүхэд байрлуулах газар үрэгдсэн (өдий хүртэл олж чадаагүй, муусайн хоолны туламнууд!)

Зинаида Львовна Волкова, Троцкийн бага охин, — амиа хоролсон.

түүний нөхөр, Платон Волков, — 1937 онд буудуулж алуулсан.

Тэдний хүү, Всеволод Волков, 1926 онд төрсөн, Парист нагац ах буюу Троцкийн том хүү Лев Седовынд суудаг.

Сергей Львович Седов, Троцкийн бага хүү — 37 оны аравдугаар сарын 29-нд буудуулж алуулсан.

Александр, Юрий, Троцкийн ач нар, — буудуулж алуулсан.

Амьд байгаа нь: үл бүтэх Троцкий өөрөө, түүний хоёр дахь эхнэр Наталья Седова, том хүү Лев Седов, бас арван нэгтэй зээ хүү Всеволод Волков. Давын өмнө Троцкийг устгах хэрэгтэй. Лев Седовыг одоохондоо хөндөх хэрэггүй. Манай агент Зборовский түүний итгэлийг лут хүлээсэн хүн, түүгээр дамжуулан бид бүрэн мэдээлэлтэй байгаа. Хөвүүн — дараа нь аавынхаа араас орно.

мань хүн тэгэхэд Троцкийг хилийн чанад руу дэмий гаргачихсан юм. Бусад муусайн шидэл шиг нь шүүхэд өгчихсөн бол ч. Өрөөсөн хөл дээр нь арван цаг зогсоход хамаг юманд гарын үсэг зурах л байсан. Рыков, Бухарин гэдэг хоёр лүд яг л Зиновьев, Каменев хоёр шиг бааснууд болж таарсан. Мэдээж, “Би намын тушаалыг биелүүлж байна, шүүх дээр өөрийн мэдүүлгийг нотлох болно” гэж “үзэл сурталтны” дүр эсгэцгээсэн. Худлаа залцгааж байгаа юм! Мөрдлөгийн аяыг даахгүй, тэгээд л өгсөн юм болгонд гарын үсэг зурж байна. Ваня Будягин яагаад ч юм бэ “намын тушаалыг биелүүлье” гээгүй. Уул нь ч түүнийг ёстой эрүүдэж өгсөн л дөө! мань хүн түүнийг харуулах гэж Андреевийг зориуд явуулсан. Гэтэл Андреев харчихаад өөрөө муужирч ойчсон, Улстөрийн товчооны гишүүний мэдрэл тийм сулхан болж таарсан. Харсан хүн нь муужирч ойчиж байдаг, гэтэл тэгүүлж байгаа хүн нь ойчдоггүй. Тэгэхээр чанга хүн. Харин гарын үсэг зурагсад бол сулхан хүмүүс. Ягода бусдыг нугалж байсан хүн, өөрийнх нь ээлж ирсэн чинь шууд л бүх юман дээр гарын үсгээ зурчихсан. Троцкий ч бас зурах л байсан. Хэрэв авгайг нь, хүүг нь, ачийг нь өөрийнх нь нүдэн дээр байцаах юм бол бүх юман дээр гарын үсэг зурах л байсан. Зурахгүй бол шоронд л мажийх байсан. Өрнөдөд шуугиан дэгдэх нь мэдээж. Тэгээд юу гэж?! Тэд шуугиад Зөвлөлт Холбоот Улсад ямар хохирол учруулж чадах юм бэ? Ямрыг ч үгүй. Ашигтай л байх юм бол хөрөнгөтнүүд шуламтай ч наймаа хийхэд бэлэн буй. Тэгэхээр Бухарин — Рыковыг шүүх ажиллагааг ч бас л тэгсхийгээд өнгөрөөнө.

Шүүх хурлыг гуравдугаар сарын хоёронд эхлэх хэрэгтэй. Өмгөөлөгчтэй, хэвлэл мэдээллийн байгууллага, дипломат корпус, сэхээтний төлөөлөгчдийг, ялангуяа зохиолчдыг оролцуулсан нээлттэй шүүх хурал. Бухарин тэдний яруу найргийн мэрэгжилтэн юм чинь хайртай хүнээ зохиолчид сонсоцгоог л дээ.

Аяархан цорхийх чимээ түүний бодлыг тасдлаа. Чих тавин чагнав... Азнасхийнээ дахиад аяархан цорхийж байна. Хүрэлзгэнэ үү? Нээрэн, хүрэлзгэнэ ч юм шиг. Энд хаанаасаа хүрэлзгэнэ байх билээ? тэрээр хүрэлзгэнийн шовсроо сонсоогүй уджээ. Магадгүй, бүр хүүхэд ахуйдаа... Горид хүрэлзгэнэ байсныг санахгүй байна... Тосгонд, цөллөгт байхдаа сонсжээ... Шөнийн цагаар шовширдог асан. түүнд саад болохгүй, харин ч аятайхан байсан, нам тайван, нам гүмийг улам тодотгоно... Бодол бодон хэвтэж байхад пийшингийн цаана хүрэлзгэнэ аяархан, өнчин янзаар шовсроно, эрээ цээргүй бус, аймхай шовсроно... Гэтэл энд чинь пийшин байхгүй, төвийн халаалттай шүү дээ. Хүрэлзгэнэ зөвхөн пийшин дээр

үрждэг биш бололтой дог оо. Надя хүүхдүүдээ Уран сайхны театрт “Пийшин дээрх хүрэлзгэнэ” гэдэг жүжиг үзүүлэхээр дагуулж явдаг байж билээ. Тэгээд л хүрэлзгэнэ пийшин дээр үрждэг гэж бодсон хэрэг, гэтэл зөвхөн пийшин дээр биш байх нь. Власикт хэлдэг юм бил үү? Яах гэж хэлэхэв? Эрж хайж, савхин гутлаараа дэвсчиж, хамаг ном ийш тийш нь сандааччихна. Хүрэлзгэнэ хэнд саад болж байна? Жоом биш, бясаа биш, хоргүй амьтан. Амьхандаа дуулж, шовширч байна, дуулж шовширч л байг, өнчин амьтан!

Сталин босч, дээл, малгайгаа өмсөөд чих тавив. Хүрэлзгэнэ чимээ ч алга. Жаахан хүлээзнэв... Байдаггүй ээ, хүрэлзгэнэ дуугарахгүй байна, зүүрмэглэсэн байх.

Сталин довжоо руу гарлаа. Харанхуй шөнө аж, уул нь шөнө болоогүй, долоо ч болоогүй байгаа байх. Байшинд нь, бас харуулын болон бусад байранд хурц гэрэл асаатай байна. Номын сангаас байшинг нь хүртэлх нарийн замыг шонгийн дэнлүүнүүд гэрэлтүүлж байна. Том хаалганы болон хашааны дагуух шовгоруудын харуулууд харагдаж байна. Сталин хоёрдугаар сарын яльгүй чийгтэй, сэрүүвтэр агаар амьсгалан зогсогносноо байшин руугаа зүглэв.

Хоолоо ганцаараа идэв. Ежов харуулын байранд хүлээж байгаа аж. Валечка сав суулгыг хураалаа. Сталин Ежовыг оруул гэж тушаав.

Цаадах нь баахан хавгастайгаа орж ирэв. Хөх нүдтэй, бүр агаалзай оргисон жаахан амьтан. Боловсрол муутай, мулгуу эрүүчин. Биеэ дааж з ө в шийдвэр гаргах чадвар байхгүй. Ялихгүй юм болгоныг түүнээс асууна, үйл болгондоо зөвшөөрөл шаардана, Дотоод хэргийн ардын комиссар мань ХҮН юмуу, Ежов юмуу, ойлгох аргагүй. Ежовыг ажлаас нь хуссаны дараа, цэргийнхний зарим нэгийг суллаж, тэднийг шудрага бусаар ялласан хэмээн харуулж болох юм. Ард түмэн сэтгэл ханамжтай хүлээж авна. мань ХҮН ч, ард түмэн ч Ежовг хууртсан байна. Улаан архичин. Архины донтон. Тэгэхээр чалчиж байгаа даа. Ийм гэрч түүнд хэрэггүй. Берияг оронд нь тавина. Берия бол тэнэг биш, шийдэмгий хүн, түүний үгийг хэлэв үү, үгүй юү ойлгоно.

Сталин сандал руу заагаад,

– Бие жаахан төдгүй байна, шуухинаа. Тийм учраас зайтайхан байгаарай гэж сэрэмжлүүлээд, – Танаар юу байна? гэв.

Ежов сүүлчийн байцаалтуудын тэмдэглэлийг ширээн дээр тавив. Сталин тэдгээрийг гүйлгэж харав. Бүх юм ёсоор. Мэдүүлэгт нэмж оруул гэж өчигдөр өөрийнх нь тушаасан зүйлд яллагдагчид гарын үсгээ зуржээ.

Сталин хавтсыг хаалаа.

– Будягин яаж байна?

– Мэдүүлэг өгөөгүй чигээрээ л байна, нөхөр Сталин. Би өөрөө байцаасан, нүүрэлдүүлэх уулзалтаар түүнийг илчлээд л байгаа, тэгсэн хэрнээ... Хэргээ хүлээдэггүй шүү, нөхөр Сталин.

Сталин Ежов руу муухай харав.

– Будягиныг та гэтлэх үү?

– Заавал, нөхөр Сталин.

– Үгүй ээ, та гэтлэхгүй. Би бүр цөллөгт байхын Будягиныг мэднэ. Тийм учраас түүнтэй та зовж байхын хэрэггүй. Будягиныг буудан хороо гэж Сталин барайж өгүүлэв.

– Мэдлээ, нөхөр Сталин.

– Троцкий юу болсон бэ?

– Чухал мэдээ байна, нөхөр Сталин. Троцкийн хүү Лев Седов өчигдөр орой Парист, эмнэлэгт үхсэн.

Сталин Ежов руу гөлөр нүсэр харцаа шилжүүлэв.

– Яах гэж үхээв?

– Би танд илтгэж байсан, нөхөр Сталин. түүний хавьд манай хүн...

– Яах гэж үхээв? гэж би асууж байна хэмээн Сталин үгийг нь тасдав.

– Нөхөр Слуцкий, Шпигельглас нарын шийдвэр байсан юм.

– Би тэднээс биш, танаас асууж байна: яах гэж үхээв?

– Седовыг үхсэний дараа Троцкий Зборовскийг Мексик рүү татаж авна гэж үзсэн юм.

Сталин ширээ шаалаа:

– Тэнэгүүд, хүний шаарнууд! Троцкий хүү нь үхсэн бол Зборовскийг хэзээ ч өөр рүүгээ татаж авахгүй. Харин ч яг эсрэгээр, улам сэрэмжлэх арга хэмжээ авна. Дүйрэнгүүд! Хорлон сүйтгэх бузар үйл ажиллагаа! Шпигельглас гол даалгаврыг хясан боогдуулж байна. Слуцкий бол Ягодагийн гар хөл. Та түүнийг яагаад өдий хүртэл байлгаад байгаа юм?

– Би танд илтгэж байсан, нөхөр Сталин. түүнийг баривчилвал манай хилийн чанадад буй төлөөлөгчдийг айлгачих учраас Узбекистан руу томилсон юм.

Сталин бодолхийлснээ, Ежов руу дахиад муухай харав.

– Явж байх нь... түүнийг сайхан гаргаж өгөөрэй.

Вадим сайхан урамтай сэрж, босон харайгаад, биеэ тавирааж гараа хэд далласнаа угаалгын өрөө рүүгээ явлаа. Замдаа гал зуухны зүг, Феня руу,

– Цайгаа тавиарай! гэж хашгарлаа. Цаад авгайн сурсан зангаараа асаасан радиогоор зөвлөлтийн хөгжмийн зохиолчдын дуу хангинаж байв.

Уул нь мань Вадим “наад хэнгэргээ унтраа” гэж нэн даруй тушаадаг байсан бол энэ удаа бүр хөгжмийн аяар хөлөө дэвслэн, аргил дуугаар даган гунгануулсан шигээ шүршүүрт оров.

Ай хө, зөвлөлт оронд амьдрах сайхан шүү,

Ай хө, эх орноороо хайрлуулах сайхан шүү,

Ай хө, эх орондоо хэрэгтэй байх сайхан шүү...

Нээрэн, сайхан өдөр, ёстой гоё өдөр... Тэгээд дуу аялсан чигээрээ гал тогоо руу залрав. Шарсан талх амтархан ханхалж байна. Феня ширээ рүү суугаад, түүнийг талимааран харав.

– Тэгэхээр Калинин өөрөө чамд одонд гарын үсэг зураа юу?

– Одонд биш ээ, Калинин шагнах тухай зарлигт гарын үсэг зурахгүй юу.

– Ээ мөн аз заяа еэ, ёстой аз заяа...

Феня түүний өмнөөс чин сэтгэлээсээ баярласан бол эцэг нь тэр мэдээнд сэтгэл нэг их хөдлөөгүй, сониныг тоомжиргүй гүйлгэж хараад өнгөрсөн аж. Уул нь дэмий л тэгж байгаа юм: энэ улсад хэдэн мянган зохиолч бий, гэтэл дөнгөж 172-хон хүнийг одонгоор шагнасан! Шолохов, Фадеев, Твардовский, Катаев, Маршак, Михалков, Гладков нарыг. Тэгвэл энэ аврагуудынхтай зэрэгцээд хүүгийн чинь нэр байж байна, аав минь, май, хар! Яаж мундаг үнэлсэн байна даа!.. Бас Фенягаас асуу, баяр хүргэсэн цахилгаан бөөн бөөнөөрөө ирж байна: олон сонин, сэтгүүлийн газраас, кино студиес, элдэв хороо, байгууллагуудаас...

– Чи давхиад хамаг найз нарынхаа урд гарчихлаа, тэр муусайн хоосон бурагчдын урд хэмээн Феня Ершиловыг дайруулж өгүүлэв. мань авгай бичиг үсэггүй ч гэсэн эмэгтэй хүний зөн билэг нь өөрийг нь юу гэж хуурах сан билээ, Ершиловыг ирэхэд дургүй, зориуд хямсайгаад нүүр эс өгнө. Хамгийн сайн найз нь гэлтэй Ершилов баяр хүргэхдээ хэрэгтэй хэрэггүй ердийн хэдэн үг бувтнасан, өөрт нь өгөөгүй байж яагаад Марасевичид өгөв гэж атаархаж байгаа хэрэг.

– Чи ч бүгдээрэнгээс нь ухаантай л даа гэж Феня нэмж өгүүлээд, багад нь тэгж байсан шигээ толгойг нь илэв.

Тэгтэл ч утас хангинасан чинь Женька Делановский юмсанж.

– За, яаж байна, Вадим, бурят-монголы?..

Пиджакныхаа энгэр дээр одон зүүх нүх “өрөмдөх” (оросын ‘бурить’ гэсэн үгээр буриад-монгол гэдэгтэй адилтган тоглож байна. Ц. Г.) хэрэгтэй болно гэж хэлэх гэсэн нь тэр. Гойд нарийн ухаан сийлсэн наргиан биш л дээ. Женька Делановский Вадимтай Кривоарбатскийн хөндлөн гудманд нэг сургуульд, гэхдээ гурван ангиар доогуур сурч байсан юм. Сурагч байхдаа л “Пионерская правда”-д шүлгээ нийтлүүлсээр “Комсомольская правда”-д нийтлүүлтлээ өссөн. Чадвартай, гэхдээ шижээргүй залуу. Бэлэн зэлэн цэцэрхэнэ, үгийн наадам болгож балайна, толгой холбохгүй ганц үг ч хэлэхгүй. Нэг удаа зохиолчдын ресторанд байхдаа Вадимаас: “Маргааш хэнийг ермиловдох гэж байна?” гэж асуусан. Тэр нь, чамайг Ермилов ивээдэг, чи түүний шивнэснээр биднийгээ шүүмжилдэг гэж байгаа ухаантай юм. Альтманд ганц үг шивнэхэд л, ээлжит мэдээлэлдээ ганц өгүүлбэр шургуулахад л энэ муу Женька будаа болно шүү дээ. Даанч жараахай төдий амьтан, аж төрж байг, амьсгалж яваг. Гэхдээ хазаарлахаас өөр аргагүй. Яруу найрагч Васильевыг ч бас хазаарлах хэрэгтэй.

– Чамайг “Веселые ребята” авсанд чинь баяр хүргэе!

“Знак Почета” одон дээрээ эрэгтэй, эмэгтэй залуу ажилчны дүрстэй учраас тэгж нэрэлдэг юм. Гэхдээ ерөнхийлж, хийсвэр тоглоом хийх нэг хэрэг, харин тийм байдлаар баяр хүргэх бол өөр хэрэг: доромж сонсдож байна, хэрэг болвол нэхэн санана аа, гайгүй.

Утас дахиад дуугарсан чинь Гослитиздат-ын Клавдия Филипповна аж:

– Зүй ёсны, яг зүй ёсны шагнал.

Бүх өдөр иймэрхүү өнгөрөв. Вадим утасны дэргэд өнжихдөө, баяр хүргэсэн үгийг сонсож, утас чимээгүй байх хооронд шагнагдагсдын нэрс бүхий “Правда”-г эргүүлсэн шиг суув: мухлагаас тэр дугаараас арвыг авсан гэж байгаа. Есийг нь ширээ рүүгээ хийчихээд, арав дахь дээр нь, Москвагийнх хэд байна, Ленинградынх хэд байна, Киевийнх хэд байна, шүүмжлэгч хэд байна, өөрийнх нь насныхан хэд байна гэхчилэн тоолж бүртгэв. Нийслэлийн залуу шүүмжлэгчдээс шагнуулсан нь чухамдаа мань хүн ганцаараа болж таарлаа.

Орой нь Вадим цуглаанд оролцохоор Зохиолчдын эвлэл рүү очив. Хамгийн алдартайчуул үг хэлцгээж, зөвлөлтийн утга зохиолын талаар эцэг ёсны халамж анхаарал тавьж байдаг нам, засагтаа, биечлэн нөхөр Сталинд талархал илэрхийлж байлаа. Нөхөр Сталины нэр дурдагдах бүхэнд нийтээрээ босч алга ташицгаана. Нам, засаг, биечлэн нөхөр Сталинд талархал илэрхийлсэн тогтоолыг нижигнэтэл алга ташин нэгэн дуугаар баталлаа.

Одоо Вадим хаана ч очсон, түүнийг хаа сайгүй баяр хөөртэй мэндчилэн угтдаг болжээ. Вадим редакцийн газруудаар очиж, хэрэгтэй юм шиг, хэлтсээс хэлтэс, өрөөнөөс өрөө дамжин хэснэ, үнэндээ бол, тэдэнд харагдах гэж, өөртөө баяр хүргүүлэх гэж, өөдөөсөө мишээлгэх гэж яваа хэрэг. Тэгээд аль нэг хэлтэст өөрийг нь анхаарахгүй байвал гоморхоно, гэхдээ өөрийнхөө өмнөөс бус, мэдээж, зөвлөлтийн утга зохиолын өмнөөс, сонин уншдаггүй муусайн дүйрэнгүүд хэмээн гоморхоно. Үзэл суртлын фронт дээр ажиллаж байгаа улс шүү дээ!

мань хүнд баяр хүргэнэ үү, эс хүргэнэ үү, ямар ч байлаа гэсэн түүний он удсан хүслэн эцсийн бүлэгт биелжээ. Нөгөө гол хүмүүс түүнийг өөрийн хүн гэж хүлээн зөвшөөрлөө.

Төрийн өндөр шагнал хүртсэн тэрбээр одоо тэдний тоонд, амьдралыг захирамжлагчид, амьдралын эздийн тоонд орлоо. Одоо түүнийг Кремлийн эмнэлэгт бүртгэж авах ёстой, манайд одон тэмдэгтэй зохиолчид олон сон бил үү? “Одонт” гэж сайхан үг, сайхан сонсдоно гээч. Францад одон тэмдэгтэй хүнийг “гавьяаны одон тэмдгийн эзэн” гэдэг. Гэтэл “эзэн” гэдэг бол нэг маягийн хөнгөмсөг, чухам франц зүгийн, хүүхэмсэг зангаас үүдэлтэй ч юм шиг. “Одон тэмдэгт” гэдэг бол цэвэр зөвлөлтийн үг, “зэвсэгтэн”, “хуягтан” гэдэг шиг, эсвэл түүнээс ч дээр “илдчин” гэдэг шиг мундаг, лужир үг, хүлэг баатруудын гавын хүн гэдгийг заана, эрсийн хийморьтой, лут сонсдоно. Тэгвэл “араараа тавиулагч”-ийн тухайд юу гэхсэн бол?

Шагнагдагсдын нэрсийн жагсаалтыг нөхөр Сталин шалгасан ч юм шиг, Михалковын бүтээлийг гойдгүй үнэлсэн гэж Катаевт уурласнаасаа болоод түүнд тодорхойлсноос нь дээгүүр одон өгсөн ч юм шиг яриа гарсан. Одоо Сережа Михалков мандаж өгнө, юу ч гэхэв, бөөн авьяас, хүүхдийн хайртай зохиолч юм чинь. Харин Катаев бол муугаа үзнэ дээ. Тэр нь ч зөв, Одессийн бүр нэг эрээ цээргүй туучий, шижээргүй, ичих нүүргүй... Ингэхэд өөрийнх нь тухай, Вадимын тухай юу гэж ярьцгаасан бол? Шагнасан болохоор сайн л юм ярьсан гэсэн үг. Гэхдээ чухам юу гэж ярив, хэн юу гэв? Магадгүй, нөхөр Сталин өөрөө ч хэлээ юм болов уу? “Марасевич гэсэн өгүүлүүд надад тааралдаж байсан... Энэ чинь тэр Марасевич үү?” — “Тийм ээ, нөхөр Сталин, тэр чинь”. — “За тийм байж, авьяастай хүн, зөв байр суурин дээр байгаа хүн. Залуу авьяасыг дэмжих хэрэгтэй” гэхчилэн. Мэдээж, иймэрхүү яриа ор тас байгаагүй ч байж болно. Нөхөр Сталин Марасевич гэж хэн юм бэ гэх маягтай зүгээр л асуугаад, цаадуул нь илтгэмэгц Сталин түүнийг нэрсийн жагсаалтад үлдээсэн байж болно. Гэтэл нарийн ширийнийг нь мэдмээр санагдаад болж өгдөггүй. Хэнээс асуудаг юм билээ? “Александр Александрович, миний талаар нөхөр Сталин юу гэсэн бэ?” гээд Фадеев дээр очилтой нь биш дээ. Цаадах нь: “Та нар танил юм гэж үү, тэр чинь таны нэрийг ч дурсаагүй шүү” гээд өөдөөс нь ээлжит хэд хоногоор уусан улаан нүдээ бүлтийлгэнэ.

Өөр бас нэг юм бий: нөхөр Сталин нэрсийн жагсаалтыг батлаж байхдаа, түүнийг, мань Вадимыг бас “Вацлав” гэдгийг мэдэж байв уу, үгүй юү? Нэрсийн жагсаалтыг Лубянкад хянаж үзээд, түүнийг үлдээсэн нь тов тодорхой. Тэгэхээр түүнд итгэж байх нь, нөхөр Сталин ч итгэж байх нь.

Одонгоо чухам хэзээ гардуулах юм бол? Мэдээж Кремльд гардуулна, мэдээж Калинин гардуулна, гэхдээ тэр одонг хэзээ пиджакных нь энгэрт зүүж өгөх юм бол, түүний одон тэмдэгт болсныг эцсийн эцэст хэзээ хүмүүс харах юм бол?

Вахтанговын театрынхнаас дарга, уран сайхны удирдагч хоёр түүнд баяр хүргэсэн бол жүжигчдээс хэн нь ч дуугарсангүй, муусайн шуламнууд, сонин уншина гэж байхгүй, дүрийнхээ үгийг цээжлэхээс өөр номын үсгэнд хавирна гэж даанч байхгүй. Уулзах болгондоо ямар нэг урмын үг хайрладаг Вероника Пирожкова хүртэл одонгийн тухай ган хийсэнгүй, мэдэхгүй байгаа хэрэг. Гомдмоор шүү. Пирожкова эндхийн бүх хүний адил түүнийг ихэд хүндлэнэ, гэхдээ тэр нь театрын шүүмжлэгчийг зулгуйддаг жүжигчдийн ердийн нохойтол биш. Бужгар шар үстэй, дүрлэгэр цэнхэр нүдтэй, өөр рүү нь дандаа жуумалзаж байдаг аальгүй амтай, 18-тай юмуу, 30-тай юмуу бүү мэд, нас нь мэдэгдэхгүй, чөргөр хүүхэн. Пирожкова түүнийг бусад шигээ Вадим Андреевич гэхгүй, зүгээр л Марасевич гэх.

Инээмсэглэл нь түүнийг чухал хүн гэж даажигнаад байгаа юм уу, эсвэл элдэвлээд байхад нь тоохгүй байна гэж дооглож байгаа юм уу, ямар ч гэсэн нэгэн зүйл тохуу буй. Гэтэл мань Вадим 28 хүрсэн ч хүүхэн үзээгүй, т и й м харьцааны асуудал үүсэхэд бэмбэгнээд явчихна, уул нь Пирожкова таалагдаад л байгаа чухдаа. түүний харц, даажинтай мишээл, эрээгүй “Марасевич” энэ тэр нь сэтгэл догдлуулна. Пирожковаг туслах дүрүүдэд ашигладаг ч гэсэн Вадим нэг шүүмждээ: “Пирожкова завсрын ч гэсэн Аннагийн хэв шинжит дүрийг үнэмшилтэй бүтээжээ” гэж тэмдэглэсэн удаатай. Вероника тэгэхэд “Баярлалаа, Марасевич!” гээд бүхний нүүрэн дээр түүнийг үнссэн билээ. Жүжигчид эр эмгүй, шалтагтай шалтаггүй үнсэлдэх дуртай, гэхдээ Пирожковагийн тэр үнсэлт түлчих шиг болсон. Үүнээс хойш мань хүн шөнө болохоор тэдний уулзалт, түүний тэврэлт, үнсэлтийг амтархан төсөөлөн, түүнийг нүцгэн байгаагаар дүрслэн бодохдоо, эцэг нь болиулсан хүүхэд ахуйн муу зуршилдаа эргэж автахгүйн тулд босч өрөөн дундуураа холхидог болжээ...

Тэгж тэгж нөгөө явдал тохиодог юм байна! Кремльд. Михаил Иванович Калинин биечлэн гардууллаа. Вадимын нэрийг дуудлаа! мань хүн явж очлоо. Михаил Иванович түүнд одонтой хайрцаг, шагнуулсан тухай үнэмлэхийг гардуулж өгөөд, инээмсэглэн гар барилаа, уул нь хүн болгоны өөдөөс инээмсэглэж байгаа л даа, гэтэл мань хүнд сайхан танилын хувиар нэг л өөриймсөг инээмсэглэдэг юм байна. Гараа ч бас зүгээр нэг албархаж өгсөнгүй, чин сэтгэлээсээ чанга атгалаа. Нөгөө танхим руу орж, бөөндөө зураг авахуулахаар сууцгаахад, эхний эгнээнд сууж байсан Калинин эргэж хараад, хэн нэгнийг харцаараа хайсан боловч олоогүй. Вадим чухамхүү өөрийг нь хайсан гэдэгт эргэлзээгүй, өөрийнх нь өгүүллүүдийг уншаагүй байж магадгүй, гэхдээ эцгийг нь мэднэ, эцэг нь түүнийг эмчилдэг юм чинь. Үүнийг хэн ч анзаараагүй нь даанч тоогүй, хүн болгон шагналаараа, өөр өөрийнхөө одонгоор бахархаж, Калинин чухамхүү өөрт нь онцгой анхаарал тавьсан, чухамхүү өөрөө л энд гол хүн гэж үзэж байгаа хойно арга ч байж уу даа.

Гэртээ ирсэн хойно Феня пиджакных нь энгэрийг нүхлэж, түүнийгээ утсаар тойруулж эмхэрдэж өгсөнд, Вадим тэнд нь одонгоо зүүж пиджакаа өмсөөд толинд харлаа. Гайхамшигтай! Феня ч бас үүдэнд зогсчихоод, баясан ашлаж байна:

– Вадимушка, сайхан байна, ямар ч гоё юм бэ, ердөө л аль нэг ардын комиссар гэсэн үг, нээрэн шүү!.. хэмээн хоолой нь чичрэн, – Сергей Алексеевич харсан бол ёстой баярлах байсан даа, тэр чамд бүр нялхаас чинь хайртай байсан юм чинь, Вадимушка минь гэв.

Солиотой авгай, тэр тэнэг үсчинг санаж гэнэ, хамаг баяр хөөдчихлөө.

Ингэхэд яагаад хөөдсөн билээ? Хөөдсөн юм юу ч алга. Үсчний явдал дууссан, түүнээс болж бүх насаараа шаналаж явах бодол алга, түүний өөрийнх нь л буруу юм чинь! Тэр байтугай толгойг хяргаж байна, тэр байтугай хүн хэргээ улайж байна, гэтэл тэр өвгөн улайхыг хүсээгүй! Энэ тухай бодохоо болих минь!

Вадим маргааш нь бас редакцийн газруудаар орж, өлгүүрт пальтогоо өгөөд, одонгоо гялалзуулан өрөө тасалгаагаар хэсүүчиллээ. Хэн хүнгүй түүнд баяр хүргэн, одонг нь бахдан харцгааж байв. Шагнуулсан тухай түрүүчийн удаа мэдэхгүй байсан хүмүүс ч нийтийн дуу

хоолойд түрлэг нэмж байна. Вадим баяр хүргэхэд нэр төртэй, даруухан байв. Энд түүний биечлэн байгуулсан гавьяа ерөөсөө байхгүй, энэ бол өөрийг нь биш, зөвлөлтийн утгазохиолыг шагнасан хэрэг, тийнхүү мань хүн зөвлөлтийн утгазохиолын өмнөөс үнэн санаанаас баярлан бахдаж байгаа болно.

Вадим орой нь Вахтанговын театрт очиж, зохион байгуулагчийн өрөөнд гадуур хувцсаа тайлаад, хэн нэгнийг хайх мэт хөшигний ар руу яаравчлан орж, бусад туслах дүрийнхний хамт Пирожкова ч жүжигтээ тоглохоор бэлтгэж байгаа жүжигчдийн өрөөний хаалгыг татвал толины өмнө эргэлдэж байгаа нүцгэн шахуу хүүхнүүд харагдав... Өө, пардон, уучлаарай... Гэвч Вероника Пирожкова түүнийг анзаарсан учир ухасхийн гараад, өрөөнд чирэх нь халаг оруулж ирэв.

– Охидууд аа, хараач, манай Марасевичийг одонгоор шагнасан байна! гээд түүнийг хүзүүдэн тэвэрч аваад зад үнсэхэд, бусад охид ч босон харайж Вадимыг бас үнсэцгээв.

– Өршөөгөөрэй, би Комаровыг хайж явна... гэж Вадим бувтнав.

– Комаровыг уу? гэж Вероника лавлаж асуугаад, – Тэр чинь энд байгаа, би танд олоод өгье гэв.

Тэр хоёр хонгилд гармагц Вероника,

– Та өнөө орой завтай юу? гэж шивнэн асуулаа.

Вадимын зүрх зогсчих шиг болох нь тэр.

– Завтай...

– Таны шагналыг тэмдэглэцгээе, би ердөө нэгдүгээр үзэгдэлд л гарна.

– Тэгдэг хэрэг. Ресторанд орцгооё.

– Үгүй, үгүй, болохгүй, хаа л бол зэс хошуутнууд, таныг оосорлож байна гээд цуурцгаана... эсвэл өөр ямар нэг балай юм ярьцгаана хэмээн Вероника толгой сэгсчив.

түүний хоолой нь чичрэн, нүдэнд нь нулимс гүйлгэнээд ирлээ... Вадим бүр айчихлаа:

– Юу гэсэн үг вэ, та яаж байна? Яагаад уйлаад унав аа? Битгий л дээ.

Хүүхэн нүдээ арчлаа.

– Би муу хэлүүлэх дургүй. Би зүгээр л таныг шагнуулсанд баяртай байна. Энэ бол миний хувьд баяр. Манайд очсон нь дээр, жаахан сууцгаая, хөгжим сонсоцгооё, би ганцаараа суудаг юм чинь, тэгэх үү?

– Тэгье гэж Вадим арайхийн өгүүлэв.

– Нэгдүгээр үзэгдлийн дараа би таныг албаны хаалганы тэнд, гадаа хүлээж байя.

Тэгж хэлээд, хацар дээр нь шовхийтэл үнсчихээд гүйж одов.

Вадим нэгдүгээр үзэгдлийг дуусгах гэж махаа идэв. Тайзан дээр юу болж байгааг харж байгаа юм алга. Хүүхэнтэй хоёулхнаа уулзана, өрөөнд нь... “Ганцаараа суудаг юм чинь...” Яагаад ганцаараа байна? Пензээс ирсэн, ямар нэг байр хөлсөлдөг байх, эсвэл нөхөртэй, нөхөр нь томилолтоор явчихсан байх... Тэгсэн чинь гэнэт ороод ирвэл?! Үгүй ээ, одон тэмдэгтэй хүнийг оролдож зүрхлэхгүй. Өөр юмнаас айдас хүрээд байна... Нөгөө юмаа чадахгүй бол яана. Хоёр ч удаа тэгсэн түүхтэй. Тэгтэл яг дахиад тэгвэл?! Гэвч зайлах аргагүй боллоо, Пирожкова гадаа, жаварт хүлээж байх нь. Бас нэгдүгээр үзэгдлийн дараа яаж гарч явна аа? Жүжиг түүнд таалагдсангүй гэж бодно, шинэхэн одон тэмдэгтийг биеэ тоосонд тооцно: таалагдсан, таалагдаагүй шүүмжлэгч хүн жүжгийг дуустал суух ёстой. Яаралтай ажил гараад л явж байгаа царайлахаас.

Вадим завсарлагаанаар зохион байгуулагчийн өрөөнд ороод, утсыг нь шүүрэн авч, хэдэн тоо эргүүлээд, цаанаас нь хүн ярьж байгаа дүр эсгэн, бүр хүмүүсийг чимээгээ аядахыг гуйж,

– За, за... Хэзээ? Өө, тийм үү... Тэгье, тэгье. Би шууд гарлаа. Тийм ээ, яг одоо. Утасдаад, намайг хорин минутын дараа очно гээд хэлчих.

Харилцуурыг тавиад, тэнд байгсадыг нухацтай харж,

– Харамсалтай нь, яаралтай явалгүй болохгүй нь!

– Нэг юм болоо юу, Вадим Андреевич?

– Дуу-даж бай-на! хэмээн хамгийн дээд газраас, магадгүй бүр ТХ-ноос дуудсан юм болов уу гэмээр донжтой өгүүлэв.

Вероника тэр хоёр Горькийн гудамжны хүнсний дэлгүүрт орлоо. Вадим хатуу улаан дарс, хиам, бяслаг, цөцгийн тос, дарсан хэмх, утсан загас энэ тэрийг Пирожковад даналзах санаатай, бэлжүү загнан худалдаж авлаа. Хүүхэн: “Марасевич, Марасевич, энэ их юмаар яах нь вэ?” хэмээн толгой сэгсрэх зуур, өөр амттай шимттэй юм юу байна гэж лангууг өлөн нүдээр нэгжин байв.

Вероника Столешниковын хөндлөн гудамны (“Яг төвд суудаг” гэж бахархан өгүүлжээ) нийтийн том байранд суудаг юм байж. Гудаагаар явж байхдаа:

– Энэ бол жорлон, энэ бол угаалгын өрөө хэмээн зааж, – Хэнийг ч тоохын хэрэггүй шүү, хотын борчуул! гэж тайлбарлав.

Хөршүүд нь сонсоно чинээ тоохгүй чанга чанга ярьж явлаа.

Ядмагхан тавилгатай жижгэвтэр өрөө аж. Вероника Вадимыг цонх руу аваачаад,

– Марасевич, хараач, ямар гоё бараатай гээч... гэв.

Хэдийгээр гадаа харанхуй, юу ч харагдахгүй байсан ч Вадим,

– Гоё юмаа гэж амыг нь дагуулав.

Ард нь нэг юм хяхтнахад Вадим эмээсхийн эргэж харав.

Хавтаст шүүгээний хаалга онгойж, хумьж хийсэн даашинз унахад, Вероника буцааж чихээд, хаалгыг нь эвхсэн сонин хавчуулан хаалаа.

– За, одоо тавхай угалчих. Амар байгаа биз, тийм байна уу?

– Их эвгэйхэн юм.

– Пиджак ч бас тонилсугай. Энд дулаахан, халаадаг юм хэмээн Вероника удирдаж гарав.

тэрээр пиджакий нь дэмнэж тайлуулаад, сандалын ар дээр нөмөргөв. Тэгээд зуушаа гаргаж тавиллаа. Тэднийх хоёрхон тавагтай юм байж, нэгэнд нь бяслаг, хиам, цөцгийн тосоо хийж, нөгөөд нь загасаа хийлээ. Талхаа зүсч сонин дээр тавив.

– Оюутан маягаар иднэ ээ. Иймэрхүү үйлчилгээнд дасаагүй юү?

Вадим эсэргүүцэх маягтай мөрөө хавчив.

– Яагаад дасаагүй байх ёстой гэж?

– Түр зуурын бэрхшээл, бас бэртэгчин ёсонд ч дургүй гэж Вероника учир битүүлэг өгүүлээд, – Марасевич, лонхоо онгойлго. Бөглөө гаргагч уу? Юу байхгүйв, тэр чинь л байхгүй. Энэ байшинд би анх удаа дарс уух гэж байна, таны одонгийн төлөө. Үнэлэж байна уу, Марасевич?

– Мэдээж, тэгэлгүй яахав...

– Лонхныхоо бөгс рүү чанга алгадчих... Харчуул яадгийг харсан уу?

Вадим лонхыг гартаа эргэлдүүлж байснаа, бөгс рүү нь дүй муутай алгадав.

Вероника дарсыг түүнээс авч,

– Алив арай өөрөөр үзье. Бөглөөг нь дотогш хийчихье, тэгээд л гүйцээ. Ингэхэд, надад халив бий гэв.

Тэгээд халиваараа дарж гарав.

– Бөглөө нь доошоо орчихно, ямар ч хор мор байхгүй...

Бөглөөг дотогш нь оруулчихаад, цамцаалтай хоёр шилэн аяганд хийж, өөрийнхийгөө өргөж,

– Төр засгийн өндөр, зүй ёсны, Марасевич, мэдэрч байна уу, зүй ёсны шагналын төлөө! гэв.

Тэгээд Вадимтай тулгачихаад, аягатайгаа ёроолгүй уучихав.

Вадим зөвхөн талд нь ортол уув.

Хүүхэн толгой сэгсрэн,

– Ингэж болохгүй, одонгийн төлөө дуустал уух хэрэгтэй, тэгэхгүй бол одон чинь энгэрт чинь зохихгүй гэв.

Вадим аягатайгаа дуулстал уулаа. Хүүхэн хэмх сэрээгээр хатган, түүн рүү сарвайж,

– Юм ид, загаснаас ав, би танд талханд тос түрхээд хачирлаад өгье гээд, тостой, хиамтай, бяслагтай талх бэлдэж өгөөд, – Гурван давхар хачиртай талх үз дээ гэв.

Вадимд тэр нь таалагдаж, загас, хиам, бяслагийг аль алийг нь амтархан идлээ. Нэмэрт нь, халамцахаас айж байгааг хэлэх үү, тэгэх юм бол ёстой чадахгүй хэрэг болно, тэр бол гарцаагүй.

Тэр зуур Вероника хоёр дахиа аягалжээ.

– Одоо таны төлөө ууя, таны театрын амжилтын төлөө, таны авьяасыг зүй ёсоор үнэлэхийн төлөө ууя гэж Вадим санал болгов.

Хүүхний нүүр хувираад ирлээ.

– Театрт ганц авьяас бол багадана. Жүжигчид бол гуйлгачингууд, хэн хүнгүй нөгөөгөө дэгээдэж унагах гэж элдэвлэнэ. За яахав, энэ тухай яримааргүй байна. Өнөөдөр бол чиний өдөр, чиний баяр... Пээ, Марсевич, би бүр “чи”-дээ хүрчихсэн байна.

– Маш сайн байна. Би ч гэсэн чамайг “чи” гэж байя.

– Тэгвэл брудершафтаар ууна гээд Вероника: – Брудершафт, брудершафт, Марсевич, Марсевич, брудершафтаар ууцгаая хэмээн аяллаа.

Тэд хоёр гараа зөрөлдүүлэн аягатайгаа ууцгаагаад үнсэлдэцгээлээ.

Вероника өөрийнхөө хундагыг ширээн дээр тавилаа.

– Үгүй ээ! Брудершафтаар ингэж уудаггүй юм!

тэрээр сандалтайгаа Вадимд тулан сууж, толгойг нь тэвэрч, удаан гэгч нь үнсээд, нүд рүү нь бас удаан гэгч нь ноцтой, бүр зовлонт харцаар харснаа, гэнэтхэн,

– Өндөг шаруулах уу? Хиамтай шарсан өндөг ямар амттай гээч! гэв.

Хэсэг хиамыг нарийхан татаж, тавганд дөрвөн өндөг, хэрчим тостой хийж аваад гал тогоо руу одов.

Вадим ганцаараа үлдлээ. Чадахгүй байж мэднэ гэх айдас түүнийг нэгмөсөн эзэмдлээ. Тэгэх юм бол, нөгөө л хуучин шигээ нууж ядсан адлал, гөлөр нойрмоглол, зугтсан харц, хааш нэг салалт энэ тэр л болно доо. Театрtaа очоод найз охиддоо: “Марасевич чинь бэлгийн сульдаатай юм” хэмээн сонин дуулгана. Ирэх хэрэггүй байсан юм, өөрийг нь мэддэг хүрээнийхнээс хүүхэнтэй холбогдох ёсгүй. Гэтэл бүтэх ч юм бил үү. Энэ Пирожковад ямар нэг итгэл төгс юм байна шүү. Бас өөрөө ч гэсэн итгэлтэй байх ёстой, эмч түүнд: “Таны бүх юм ёсоор байна, гагцхүү самгардах хэрэггүй, бүгд л үүнийг чинь дамжиж гардаг юм” гэж шулуухан хэлсэн. Өнөөдөр л бүх юм болох ч юм бил үү. Болохгүй бол согтсон дүр л эсгэхээс. “Намайг хэт уулгасан чиний л буруу” гэчихнэ.

Вероника хайруулаа тавгаа барьж ирээд, шарсан өндгөө хэрчин хувааснаа, дарснаас хоёр биендээ аягаллаа.

– Алив, аз жаргалын төлөө ууцгаая. Аз жаргалын төлөө, Марасевич!

– Чиний аз жаргалын төлөө! Чамайг азын тэнгэр ивээж яваг!

түүний нүдийг дахиад нулимс бүрхээд ирлээ.

– Чи яачихав, юу болчихно энэ вэ? хэмээн Вадим сандрав.

Хүүхэн нүдээ арчив.

– Өө, шалихгүй юм, элдэв юм санаанд ороод. Болоо, жирийгээд байя!

тэрээр шарсан өндөгөөр даруулах зуур ярьж алдлаа:

– Одоо манай театрынхан чамаас улам айдаг болно, харж л байгаарай! Тэд нар хүндэлж байгаа царайлна, үнэндээ бол айцгааж байгаа юм. Манай авгай хүүхнүүд, ардын, гавьяат гээд ялгаа байхгүй, цөмөөрөө банзалууд, чи л нэг шүүмждээ магтчих юм бол аль нь ч гэсэн дор чинь хэвтээд л өгнө. За тэд нар ч яахав, нохой гахай руугаа тонилцгоог! Алив, бүжиглэе!

– Би бүжигт муу! Нэмэрт нь уучихлаа гээд Вадим шил рүү заав.

– Чи юу уусан юм бэ?! Юу шалихав! За яахав, бүжиглэмээргүй байгаа бол хөзөрдөө гэнгүүт гарт нь хэр даг болсон хөзөр ороод ирэв. Хаанаас гаргаад ирсэнийг Вадим анзаарсангүй.

– Амархан тоглоом, хар даа, би дээрээс нь нэг хөзөр авна, чи улаан уу, хар уу гэдгийг л таана. Таачихвал би нэг юмаа тайлна, таагаагүй бол чи нэг юмаа тайлна. За, Марасевич, хэлээрэй! Хар уу, улаан уу?

Ийм тоглоомыг огт сонсоогүй Вадим балмагдан,

– Улаан гэж бувгнав.

Хүүхэн дээд талын хөзрийг сөхтөл дөрвөлжингийн долоо байв.

– Ноёд оо, хараач, Марасевич таачихлаа! Би хожигдлоо, бүсээ тайллаа гээд бүсээ тайлав.

– Дахиад таагаарай!

– Улаан гэж Вадим шивнэн өгүүлэв.

Хүүхэн хөзрөө сөхсөн чинь бундангийн тамга байв.

– Дахиад таачихлаа. Марасевич, чи чинь бүр далдыг харагч шиг юмаа.

тэрээр босч даашинзаа толгой дээгүүрээ тайлсанд, нарийхан мөрөвчтэй, хөх нь харагдахаар задгай энгэртэй торгон дотуур хослолтой болов.

Вадим чиглэж харахаасаа эмээж байв.

Вероника хөзрөө дахиад гартаа авлаа.

– Ямар өнгө вэ?

Вадим дахиад,

– Улаан гэв.

Хөзрөө нээвэл цэцгийн хатан байж.

– Таасангүй ээ, Марасевич, таасангүй гэж Вероника баярлан дуу алдав. – Бурхан үнэнийг харж байна, чи туж хожно гэж байхгүй шүү! Нэг юмаа тайч!

– Зангиагаа тайлья гэж Вадим хулчганан бувтнав.

Хүүхэн өөрөө зангиаг нь тайлж ширээн дээр тавив.

– За яваад байя!

– Хар...

Дөрвөлжингийн арав гарч ирэв.

– Би цагаа авлаа гэж Вадим өгүүлэв.

– Марасевич зальтай амьтан! Цаг чинь ямар хувцас юм уу? Ноосон цамцаа тайл! Тайл, хонгор минь, тайл, булхайцахгүй шүү... гэснээ хөзрөө гэнэтхэн ширээн дээр шидчихээд, – Хөөе, Марасевич, чи бид хоёр чинь юу гээд хүүхдийн тоглоом тоглож, цаг алдаад байна аа? Би чамд таалагдаж байна уу? гэсэнд, Вадим,

– Мэдээж, мэдээж гэж бувтнав.

– Чи ч бас надад таалагдаж байна, алив орондоо орцгооё, бид чинь насанд хүрсэн, ухамсараа

мэдэх улс шүү дээ, хувцсаа тайч, алтан хүү минь гэснээ, дотоожныхоо хормойг сөхөн, татуурганыхаа товчийг мултлан урт оймсоо тайлаад, – Гэрлээ унтраачих уу?.. гэв.

түүний харанхуйд яаж хөдөлж, ороо яаж засаж, бамбай нь яаж хяхтнахыг Вадим сонсголоороо мэдэрч, тэгтэл ч дуу нь гарлаа:

– Одоо Марасечид дэвсгэрийг нь бүлээсгэж өгнө өө, сайхан дулаахан болно, за, Марасевич, наашаа ороод ир, битгий ай, бүх юм сайхан болно... Алив, нааш ир, бондгорхон минь, алив гараа гээд гарт нь хүрснээ, биеийг нь дагуулан тэмтэрч, дотуур өмдөө тайлахад нь дэм болов. – Чамгүй ор дэвсгэр бол гуниг, Марасевичгүй ор ямар олиг байхав... Хэвт, хонгор минь, хэвт, юунаас ч айх хэрэггүй... Би өөрөө бүгдийг нь яачихна, чи сайхан болно... Хараарай, гайгүй!

Үнэхээр ч сайхан бүтлээ. Туршлагатай, сурамгай хүүхэн бүх юмыг ёсчлон болголоо. Вадим анх удаагаа цэнгэл эдэлж, ямар ч байсан эр хүн гэж өөрөөрөө бахархлаа. Дахьсан чинь бас бүтсэн гээч! Вероника: “Зүйтэй, хонгор минь, зүйтэй, сайн байна, битгий яар, сайхан тайван, яг тэгээд, аа-хаан, зүйтэй, зүйтэй!” хэмээн чих рүү нь халуу оргиулан шивнэж байлаа.

Хүүхний уян налархай биенээс халуу дүүгэж, мань хүн жижигхэн хөхөн дээр нь гараа тавилаа. Цаадах нь өөрийнхөө гараар дээрээс нь дарж авч байна.

– Манайхны эмс чинь тэлээгүй банзлууд, сорьцны тамга тавих газар ч байхгүй. Гэтэл онгон дүр эсгэж яаж маяглана гээч! Дор чинь хэвтээд өгөх нь гарцаагүй, гэхдээ урьдаар онгон болж жүжиглэж алдана. Харин чи бол надад таалагддаг юм, энэнээс бол сэжиглээд сүжиглээд байх юм надад алга. Маяглахын хэрэг юу байх билээ? Марасевич, би зүйтэй ярьж байна уу?

Вадим зөвшөөрөн,

– Мэдээж, мэдээж гэнэ.

тэрээр Вероникагийн бөөрнөөс шахан, биенийх нь тачаал өдсөн үнэрийг шимтэн амьсгалж, аргагүй аз жаргал эдлэн, харанхуйд инээмсэглэн хэвтэв.

Залуусын цалинг Нонна тавьж өгнө. Гуч эргэм насны ажил хэрэгч, сэргэлэн хүүхэн. Семён Григорьевичийн туслах, бас нууц амраг нь. Цалингийн цэсэнд хүн бүр гарын үсэг зурна, бүх юм ёсоороо, бүх юм номоороо.

Нэг удаа бүгдээрээ цалингаа зэрэг авч таарчээ.

– Ийм учралаар сэржим өргөх хэрэгтэй гэж Глеб айлдав.

– Чухам аа чухам гэж Лёня гүндүүгүй санал нийлж, – Өглөөгүүр Стаканов, өдөр нь Бусыгин, орой нь Кривонос гэв.

Эдгээр нь цуутай хөдөлмөрийн сайчуудын нэрс. Лёня Стахановыг Стаканов болгосон хэрэг, Бусыгин гэдэг бол “бусой” — согтуу, хөлчүү гэсэн үг, “Кривонос” гэдэг нэрийг хэлэхдээ Лёня хөлчүүрхэж яваад нармийлгасан гэх утгаар хуруугаараа хамраа хажуу тийш нь шахаж үзүүлжээ.

Каневский дуугарахгүй байж. Глеб түүнээс,

– Яагаад дуугарахгүй байна? Цуг явцгаая л даа гэхэд цаадах нь,

– Харин ээ, би гэртээ, байрныхаа эзний бэлдсэн хоол ундаар болчихдог юм л даа гэж дүлэгнэн хариулав.

– Цуг ажиллацгааж байна, цалингаа авцгаалаа, угаадаг ёс гэж байна!

Каневский хямсайсхийж,

– Тийм ёстой юм бол тэгье л дээ! гэв.

– Гэхдээ чи биднийг нэг их гийгүүлж байгаа юм биш шүү. Бид бол нэг хамт олон, бие биенээ түшиж байх ёстой гэж Глеб анхааруулав.

Каневский хариуд нь харамсаж адалсан янзтай хямсалзав.

Ресторанд ороод хөгжмийн тайзнаас хол, тэртээ буланд тухлан сууцгааж, шил архи, нэг нэг аяга пиво, төмстэй май загас захиалцгаав.

Глеб Каневскийд архи хийх гэтэл цаадах нь хундагаа алгаараа таглаж,

– Баярлалаа, би архи уудаггүй гэв.

– Тэгвэл чамд оргилуун дарс захиалах уу? Ямрыг захихав? Манайх уу, франц уу? Каневский, чи мөн мундаг хувиа бодогч юмаа, найр битгий түйвээ л дээ.

– За яахав гээд Каневский гараа татав.

– Өө ёстой эр хүн! Манайхан ийм л байх ёстой хэмээн Глеб цагаан шүдээ яралзуулан инээв.

Бүгд ууцгааж, зуушнаасаа даруулаад, дахин нэг хөнтөрцгөөлөө. Тэгтэл Глеб бас нэг лонх архи, нэг нэг аяга пиво, гахайн шарсан мах захиалав. Саша Каневский рүү санаа зовсон байдалтай байн байн харж байв. Уудаггүй хүн, согтчих юм бол гэрт нь хүргэж өгөх энэ тэр гээд бөөн ажил болно, ядахаар, хаана ч суудаг юм бэ, бүү мэд. Тэгээд Каневскийд нэмж уулгах хэрэггүй гэж Глеб рүү дохьсон боловч цаадах нь,

– Сайхан наргиж байна! Алив, Уфа хотод төдийгүй бүх Башкир даяар өрнөд европын бүжиг хөгжин цэцэглэж байхын төлөө ууцгаая! Би зүйтэй ярьж байна уу, Саша? гэв.

– Зүйтэй ярилгүй яахав, гэхдээ Мишад одоо болно гээд Каневскийн хундагыг өөр рүүгээ тавьж, – Чи дургүйцэхгүй биз дээ? гэв.

– Дургүйцээд байх ч юу байхав, уусан ч чадна, уухгүй байсан ч чадна хэмээн Каневский хямсайв.

– Юм ид! Ямар гоё шарсан мах байгааг харж байна уу? Өөхтэй. Надад нэг настай жолооч: өөх тостой юмаар даруулж бай, тэгвэл согтдоггүй юм гэж сургаж байсан шүү.

– Тэр ч яг шүү, өөх тос чинь охийг өөртөө шингээж аваад, мах бодид нэвчүүлдэггүй юм гэж Лёня хөндлөнгөөс нотлов.

Каневский таваг руугаа тонгойн,

– Тэгье ээ тэгье. Юм идэх ёстой юм бол юм идье, өөх тостойг гэж байгаа бол өөх тостойг идье гэв.

За ямай чухам! Гахайн махыг сайхан гударч байна, арай мал болчихоогүй бололтой.

Глеб дахин хундагаа өргөв:

– Би түрүүчийнхээ үгийг үргэлжлүүлмээр байна. Тэгэхээр, өрнөд европын бүжиг башкирын бүх ард түмний дунд: башкир, татар, орос, украин, еврей, черемис, мордва, чуваш гэх мэт бүх ард түмний дунд түгэн дэлгэрэхийн төлөө... Зарим хүмүүс биднийг оромдогчид гэж байна, хүмүүс үйлдвэрлэл дээр хөлсөө гоожуулан хэдэн юм олж байхад, та нар хөлөө тийчлээд л мөнгө хамж байна гэх маягаар биднийг нүд үзүүрлэж байгаа. Үгүй шүү дээ, эрхмүүд минь! Бид нар бол урлагийн хүмүүс, социалист соёлын хүмүүс, соёлгүй социализм гэж байдаггүй юм!

Тэгсэн чинь Каневский гэнэтхэн,

– Таны ямар социализмын тухай ярьж байгаа нь ойлгомжгүй байна гэлээ. Глеб самгардан,

– Юу гэсэн үг вэ?! Би манай социализмын тухай, манай оронд ялсан социализмын тухай л ярьж байна гэв.

– Социализм манайх юм уу, манайх биш гэж байж болохгүй. Социализм гэдэг бол үнэмлэхүй ойлголт. Германы фашистууд өөрснийгөө социалистууд гэж нэрлэж байгаа. Ер нь бол арми, сэргийлэх, хүчирхийллийн бусад хэрэгсэл байгаа цагт жинхэнэ утгаараа социализм гэж байхгүй гэж тавгаа шагайн өгүүлэв.

Глеб балмагдан дуугүй байснаа малилзан инээмсэглэж,

– Үгүй ээ ер, Каневский чинь улстөрийн хувьд бэрх бэлтгэлтэй нөхөр байх нь, би даанч мэдэхгүй явж шүү гэснээ яарах шинжтэй,

– За тэр ч яахав, сүүлчийн хундагаа тогтооцгооё, залуус минь гэв.

Каневскийгээс бусад нь татацгаалаа. Глеб тооцоогоо бодуулж, нэг хүнд хэд оногдохыг хэлсэнд цаадуул нь мөнгөө гаргаж өгцгөөлөө. Гадагш гарцгаахад оройн арван цаг болж байв. Бороо шивэрч байна. Каневский бөгтөсхийн пальтоныхоо захыг босгов.

– За, хэн хаашаа явах вэ? гэж Глеб асууж байгаа ч юм шиг, тийм байдлаар салж ч байгаа юм шиг өгүүлээд Сашатай хамт яваад өгөв.

Тэгээд хэд алхсанаа,

– Юу гэмээр байна, ялдам минь? гэж асуув.

– Юун тухай тэр билээ?

– Каневскийн тухай. Нэг оронд социализм байгуулах боломжгүй гэнэ. Энэ чинь Троцкийн онол шүү дээ. Сана даа, ялдам минь.

Глебийн зөв, гэхдээ Каневскийг живүүлэх хүсэл байсангүй.

– Тэр чинь манай тухай биш, Германы тухай, фашист улсын тухай л ярих чинь билээ.

– Үгүй шүү, ялдам минь, намайг тиймхэн юмаар мунхруулж чадахгүй. Цаадах чинь юу гэж хэлсэн гээч? Арми, сэргийлэх байгаа цагт ерөөсөө социализм гэж байхгүй... “Цагдаа” гэхгүй “сэргийлэх” гэж байна шүү... Ялдам минь! Энэ чинь Зөвлөлтийн тухай л хэлж байгаа хэрэг.

– Сэргийлэх, цагдаа, үхсэн хойшоо! Битгий ямааг тэмээ болгоод бай.

– Хэрэв энэ үг маргааш т э н д мэдэгдсэн байвал яах вэ гээд Глеб ДЯАК-ын газар байдаг Егор Сазановын гудамжны зүг толгой дохив.

– Хаанаас олж мэдэх юм?

– Хаанаас аа? Тэмээнээс! Надаас гэж саная л даа.

– Өө тийм бий?!

– Харин тийм! Чи намайг бүрэн мэдэх юм уу? Гэтэл чамаас ч дуулж магадгүй!

– Өө бүр тиймдээ хүрсэн үү?!

– Тийм шүү, ялдам минь, бүр тиймдээ хүрнэ. Би ч гэсэн чамайг бүрэн мэдэхгүй. Лёнягаас ч мэдэж авч магадгүй. Чи бид хоёр хоёулаа түүнийг мэдэхгүй. Эсвэл Каневскийгээс өөрөөс нь. Тэр чинь хэн юм бэ? Манийг гулдчиж аваачаад, тэр хүн тийм юм ярьсан уу? гээд асууна. Ярьсан. Яагаад мэдээлээгүй юм бэ? Ингээд л “мэдээлээгүй” гэдэг зүйл анги тохчихно. Сайнаар яривал тэр. Муугаар бол трюккист бүлэг болчихно.

Глеб гэнэт зогтусч, нүүр нь минчийчихсэн Саша руу эргээд, нудрагаа савчуулан, бараг хашгачих шахан үглэж гарав:

– Би заримдаа өлссөн үнээ шиг мөөрөх дур хүрэх юм! Хүнийг цугтаа жаахан байя гэж урьсан бол, номхон томоотой суугаад, анд нөхдийнхөө дунд хүн шиг байх хэрэгтэй биз дээ... Тэгэхэд чинь үгүй шүү, заавал дэмий балай юм чалчина, маяглана, бусдадаа яршиг төвөг удна!

түүний ийм байдалтай байхыг Саша анх удаагаа харж байгаа нь энэ.

– Тайвшир, хийрхэж цухалдах шалтгаан би л лав харахгүй байна. Юунаас айгаав, үхсэн хойноо! Биеэ барь. Хүмүүс айсандаа ийм явдлыг дэвэргэчихээд, дараа нь өөрсдөө үүнээсээ болж зовдог юм.

Тэр хоёр нэг булан дээр иртэл Глеб,

– Би ийшлэнэ гэж санаанд оромгүй тайван хэлэв.

– Миний хэлсэн юмыг чи ямар ч гэсэн бодоорой.

– Заавал бодно оо, заавал хэмээн Глеб амлав.

– Нойроо сайхан ав, өглөө сэргэг толгойгоор бодож үзээрэй.

– Яг тэгнэ ээ, ялдам минь. Шараа тайлж байгаад бодно.

Тэнэг явдал. Каневский бол голын хийтэй тэнэг толгой. Хэзээ нэгэн цагт хэрэгт холбогдоно, бас бусдыг ч хөөднө. Гэхдээ өнөөдрийн яриа бол юу ч биш. Глеб л өвчигнөөд байхгүй бол энэ явдал ингээд дуусна.

Энэ явдал үүгээр дууссангүй.

Хоёр хоногийн дараа Саша Стасик гэдэг шинэ хамсран хөгжимдөгчтэй болжээ. Төгөлдөр хуур, баян хуур дардаг, шаламгай, хөгжилтэй хөвүүн. Ажлаа дорхноо гартаа оруулаад авч. Гэхдээ Лёня шиг бас “сонсголынх”, нот уншиж чадахгүй. Мэдээж, Каневскийн ур дүйн хаана нь ч үгүй.

Орой ресторанд хоол идэж байхдаа Саша Глебээс,

– Каневский хаачсан бэ? гэж асуув.

– Бид одоо Каневскийгүй болсон. Семён мань хүнийг халчихсан.

– Яасан гэж тэр вэ?

– Одоо бид хотын зах руу, элдэв гоймонгийн үйлдвэр энэ тэр рүү шилжицгээнэ, тийм газар чинь төгөлдөр хуур байхгүй, тэгэхээр гурав дахь баян хуурч хэрэгтэй. Стасик бол над шиг хос мэрэгжилтэй.

Саша хундагаа ширээн дээр тавив.

– Чи худлаа л залаад байна шүү дээ.

– Больж үз, ялдам минь, чи юу гээд салахгүй байгаа юм бэ?

– Чи Семёнд юу гэж хэлсэн юм?

– Чи бүгдий нь мэдмээр байна уу?

– Тэгмээр байна.

Глеб хундагатайгаа хөнтөрч, хэрчим май загас сэрээдэж авав.

– За тэгвэл аан гэж бай. Би: энэ Каневскийгээс сал, дэндүү чалчих юм гэж хэлсэн.

– Чухам юу чалчиж байгааг нь чи Семёнд хэлсэн үү?

– Хэн юу чалчиж байгааг Семён мэдэхийн хэрэг юу байна? Мэдэж байгаа юмныхаа төлөө бас хариуцлага хүлээх ёстой. Каневский цалин бага байна гэж чалчсан байж ч болох? Семён мануухай биш, ялдам минь, хүн чалчиж л байгаа бол түүнээс салсан нь өлзийтэй.

тэрээр өөртөө дахин хундагалаад, Сашагийн жүнз рүү харав.

– Өө ингэхгүй шүү. Энэ шилийг намайг барна гэж бодоо юу?

Хоёулаа ууцгаалаа.

– Чи хүнийг балласан байна гэж Саша өгүүлэв.

– Би юү дээ?! Чи чинь юу яриад байна аа?

– Үмх ч талхгүй, гудамжинд хаячихаж.

– Бүү санаа зов, тэр чинь үмх талхгүй хоцроно гэж байхгүй гээд Глеб найрал хөгжмийнхөн рүү дохиж, – Үмх талх чинь энэ байж байна, зүгээр ч үгүй цөцгийн тостой талх гэв.

– Каневскийг чалчдаг гэж чи Семёнд яагаад нэмж хэлж байгаа юм? Даацтай болгох гэж тэр

үү, гарцаагүй халуулах гэж тэр үү?

– Тийм шүү, ялдам минь, чухамхүү тийм зорилгоор нэмж хэлсэн юм. Хүмүүсийн дэргэд донгоссон юмнаас нь болж маргааш шоронд орж мэдэхээр балайтай хамт ажиллах хүсэл надад алга.

Саша дуугарсангүй.

– Намайг буруушааж байна уу? гэж Глеб асуув.

– Тэгж байна.

– Өө тийм бий, за яахав!.. гээд Глеб тамшаалснаа хундагаа дүүргэж татчихаад, зуушнаас амсалгүй, нэгэнтээ зогьсуулав. Нэлээд халамцаж байна.

– Найзынхаа тухай нэг явдлыг чамд ярьж өгье. Сонсмоор байна уу?

– Сонсож болох л юм.

– Тэгвэл аан гэж бай.

Глеб галуун хүзүүтийг өргөж харвал нэгэнт хоосорсон байв.

– За, ялдам минь, тэр явдлыг чамд ярьж өгье, тэгээд нэг нэг зуу татчихъя. Надад нэг найз байлаа, сайн найз, үнэнч найз, Ленинградд. Бид нэг байшинд, нэг орцонд, нэг давхарт амьдрана, нэг сургуульд сурна. Тэр маань утга зохиол, тоо, тэр ч бүү хэл, биеийн тамираар хүртэл тэргүүний сурагч. Новгородын жирийн борчуулаас гаралтай, гэхдээ цөлх ухаантай! Ломоносов л гэсэн үг! Их сургуулийн физик-математикийн салбарт уралдаант шалгалтаар нэгдүгээр байраар орсон. Үзэл сурталтай. Бүр есдүгээр ангид байхдаа Карл Марксын “Капитал”-ыг уншчихсан. Архи уухгүй, садарлахгүй, харин тамхи татна. Хүрэн халиун үстэй, хөх нүдтэй, тэвхэлзсэн сайхан эр! Тэгээд хамгийн гол нь сайхан сэтгэлтэй, хүн болгон түүн дээр очно, хэнд ч бай чадах юмаа хийж туслана. Тэгсэн чинь юу болсон гээч... Нөгөө найз маань оюутан байхдаа троцкист сөрөг хүчин рүү тавиад орчих нь тэр, үзэл бодлоо нуухгүй, сургууль дээр үгээ ил тод хэлнэ! Нам бус, үзэл сурталгүй надтай яагаад найзалж байсан юм гэж чи асуух уу? Би хөнгөхөн хүн, гэхдээ з ө в хүн, ялдам минь, тэр үүнийг мэдэж байсан юм. Үүнээс болж л надад хайртай байсан гэж бодож байна. Тэгээд хамаг юмаа надад ярина. Мэдээж, элдэв нууцаа дэлгэхгүй, хүн харыг нэрлэхгүй, баривчилгаа, цөллөг энэ тэр хэдийн эхэлчихсэн юм чинь, гэхдээ үзэл бодлоо нуухгүй ярина.

Глеб үйлчлэгчийг хуруугаараа дохиж дуудаад галуун хүзүүт рүү зааж,

– Дахиад хоёр зууг хөөгөөд ир! гэхэд Саша,

– Болох юм биш үү? гэв.

– Зүгээр, зуу зууг татчихад гэмгүй.

Глеб хоёр биендээ хундагалав.

– Тэр маань нэг хүнийг яс махнаасаа үзэж чадахгүй.

Тэгж хэлээд нүдээ хялайхад нь Сталины тухай ярьж буйг нь Саша ойлгов.

– түүнийг “Хувьсгалыг авслагч” гэнэ. Би тэр болгон яриаг санахгүй байна, харин чухамхүү тэр нэг орон дахь социализмын тухайд сайтар тогтоосон юм. Тийм учраас л Каневский миний жидүүг тэгтлээ хөдөлгөчихсөн юм, ялдам минь. Урьд өмнө бол энэ тухай итгэлтэй найзаасаа сонсож явсан, гэтэл Каневскийг би мэдэхгүй шүү дээ. Социализмыг нэг оронд байгуулж болохгүй гэж миний найз ярьдаг байсан юм. Болно гэж ярьж байгаа хүмүүс бол манай орныг “бүслэгдсэн хэрэм”, “дайсанд хүрээлэгдсэн цайз” болгон хувиргахыг хүсч байгаа, өөрөөр хэлбэл, уг чанартаа бол дайны байдал тогтоож, нэг хүн ганцаараа дарангуйлж байх, алан хядлага, залхаан цээрлүүлэлт явуулж байх нөхцөл бүрдүүлэхийг хүсч байгаа юм. Бас манай оронд социализмыг нэгэнт байгуулчихсан юм шиг нотлоно гэдэг бол социализмын жинхэнэ үзэл санааг гутаана, эцсийн бүлэгт түүнийг авслана гэсэн үг гэдэг байсан юм.

мань хүн чимээгүй болж, дуниартсан нүдээрээ Саша руу гөлрөн харав.

– Наад яриаг чинь дараагийн удаа хүртэл хойшлуулъя.

Глеб түүн рүү духан доогуураа хялайн харав.

– Илүү юм бурж байна гэж бодоо юу? Үгүй шүү, заяа нь тэгэхгүй, хэзээ ч!

Ширээ түшин босоод,

– Явж шээлээ... Чи цай захиалчих, маш аагтайг шүү, чифирь шиг. Чифирь гэж мэдэх үү?

– Мэднэ. Үйлчлэгч мэдэхгүй байж магадгүй.

– Тайлбарлаж өгөөрэй.

Тэгээд дайвлах маягтай, энд тэнд гишгэлэн жорлон руу зүглэв.

Сонин дүр зураг тодорч байна. Бас санаандгүйг нь яана. Хэдийгээр хөдөөний ч гэсэн зүгээр нэг балгагч, зүгээр нэг тэнэмэл хөгжимчин биш болж байна. мань хүн Глебийг тийм гэж бодоод сурчихсан билээ. Дандаа сэрдэж сэрэмжилж байдаг хүн чинь нэг троцкистын тухай талтай ярьж байх юм, уул нь одоо бол троцкистуудыг гагцхүү харааж зүхэж л болох билээ. Нэг бөглүү тосгонд хамтралчин хүүхэн хориод оны хуучин завхай дуунаас: “Би өөрийнхөө гоёд ёстой итгэлтэй байна даа, Троцкий авдаггүй юм бол Чичеринтэй сууна даа” гээд дуулчихаж. Тэгээд “троцкист суртал ухуулга” хийсэн хэргээр арван жилийн ял авсан гэж байгаа. Нэг хүн: “Троцкий дэлхийн зиндааны уран илтгэгч байсан” гээд бурчихсан — бас л арван жил. “Троцкий мэдээж дайсан, гэхдээ дээр үед Лениний дараах хоёр дахь хүн байсан” — бас л арван жил. Байдал нэг иймэрхүү. Гэтэл Глеб ийм илэн далангүй ярьж байдаг...

Үйлчлэгч суурьтай хоёр шилэн аяга цай авчирч тавив. Бараг хар гэхээр өтгөн хүрэн цай, цайнд түлсэн ёотон ч билүү нэг юм хольж байгаад тийм өнгөтэй болгодог, юу хольдгийг Саша мартжээ.

Глеб сэргэчихсэн, инээд алдсаар буцаж ирэв. Толгойгоо хүйтэн усаар шавшсан байх, нойтон үсээ самначихаж. Цайнаас том балгаад,

– Болж байна! Чи бид хоёр чинь юун дээр зогслоо, ялдам аа? гэв.

– Чамайг энэ яриагаа дараачийн удаа дуусгахыг би санал болгосон.

– Өө тэгж ярихгүй. Нэгэнт яасан хойно чи дуустал нь сонс.

Глеб ямар их ууж чаддаг, тэгээд хэрэгтэй бол яаж амархан согтуу нь гардгийг Саша байнга гайхдаг билээ. мань хүн авчирсан архиа хичээлийн өмнө, тэр ч байтугай хичээлийн дундуур ууна, гэхдээ хөгжмийнхөө аяг алдана гэж хэзээ ч байхгүй.

– Миний найз тийм хүн байсан юм, мэдээж, түүнийг аль хориод оны сүүлээр шоронд хийчихсэн. Нэг их удаан суугаагүй, нэр цуутай троцкийчууд, намтай санал зөрөлдөх юм одоо байхгүй, намынхаа шийдвэрийг дагаж байна, намын эгнээнд сэргээн тогтоохыг хүсч байна

гэх маягийн өргөдөл өгч эхэлцгээсэн. Тэднийг цөллөгнөөс нь буцааж, миний найз ч Ленинграддаа буцаж ирсэн. Манайхаар орж гарна, бид хоёр ярилцаж сууцгаана, мань хүн бүх юманд урам нь хугарч, гагцхүү шинжлэх ухаанаар оролдохоор шийдсэнийг нь би ойлгосон. түүнийг сургуульд нь буцааж авсан, нэг сайн охинтой сууж, хүүтэй болсон, тэрэндээ амиа тавина, оюутны тэтгэлэг мэдээж жаахан, физик, математик гадуур заана. Бүх юм мөрөөрөө хүнийх шиг болох нь тэр. Намынх нь гишүүнчлэлийг аяндаа сэргээсэн, ёс төдий бүртгэлтэй, гишүүн гэдэгтээ их гутрана, тэгээд хурлаа дандаа таслана, намынхаа даалгаврыг биелүүлэхгүй, идэвхгүй гэж намаасаа хөөгдөөд амар жимэр аж төрнө гэж найдаад байхгүй юу. Гэтэл юуных нь амар жимэр аж төрөх байх вэ дээ.

Глебийн хоолой зангиран, хэсэг зуур чимээгүй болж, ширээ тохойлдон толгойгоо хоёр гараараа базаж авав.

– Алив, дахиад нэг нэг зуу татчихъя...

Үйлчлэгч дахин хоёр зуун грамм авчирч өгөв. Глеб уучихаад хэрчим хиам авч зажлав.

– Тэгтэл... Цөллөгт хамт байсан нөхөд нь манай хүн дээр ирдэг боллоо, элдвийн юм яриад эхэлцгээлээ. Тэгэхэд Гитлер засгийн эрхэнд гарч, нөгөөдүүл тэр тухай ярьцгааж байгаа хэрэг. Гитлер, Сталин хоёр дүндээ дүн гэх маягийн юм ярина, ойлгож байна уу? Өөр хоорондоо элдвийн юм бурцгаана. Уул нь тэр тэнэг золиг: надад улс төр хамаагүй, энэ сэдвээр ярилцахаа больцгоо, эсвэл үүнээс хойш манайд ерөөсөө битгий ирцгээж бай гээд тас цохих хэрэгтэй байсан юм. Гэтэл сачий нь дутсан уу, яасан, ер нь ч зөөлхөн хүн, эсвэл тэр цөллөгт хагацаж салахын аргагүй сайн нөхөрлөл үүсдэг юм уу, эсвэл бэртэгчин, тэр ч бүү хэл, хулчгар цол авахаас айсан уу, тэр хүмүүстээ итгэдэг, өөр шигээ журамт хүмүүс гэж үздэг байсан ч байж магадгүй. Тэд нар нь журамт хүмүүс байсан байж магадгүй, гэхдээ ам мэдэн донгосогчид, шорон, цөллөгнөөс ямар ч сургамж аваагүй, тийм болохоор зөвхөн миний найзынд ч чалчдаггүй байсан хэрэг... Ямар ч гэсэн хоёр дахь удаагаа тэднийг ирэхэд, нийтийн байрны ганц өрөөнд байдаг болохоор хүүхэд нь унтах ёстой, өөрөө ч орой үдшийн цагаар ажилладаг учраас гэртээ хүлээн авч байх боломжгүй гэдгээ тэдэнд, боловсон хүн юм чинь, эелдгээр ойлгуулж. Тэгээд цаадуул нь үзэгдэхээ больж. Ингээд дуусвар болжээ гэж мань хүн бодож байж. Гэтэл үүгээр дууссангүй. Нэг өдөр сургууль дээр нь нэг аятайхан залуу ирж, мань хүнийг хажуу тийш нь дуудаж улаан үнэмлэх үзүүлээд: “Та надтай цуг энүүхэнд нэг газар очих ёстой байна” гэж. Тэр хоёр Том байшинд ирж; манай тэнд ДЯАК-ын газрыг тэгж нэрлэдэг юм. Дарга түүнийг сандалд суулгаад, цөллөгийн дараа яаж төвхнөв, гомдоож зовоож байгаа явдал байна уу? гэж асуужээ. Манай найз: “Бүх юм дажгүй байгаа, гомдоож байгаа хүн байхгүй” гэж хариулж. – “Цөллөгт хамт байсан нөхөд чинь ямар байгаа вэ?” Найз маань урхийг мэдэрсэн хэрнээ баримжаагаа сайн олсонгүй: “Мэдэхгүй ээ, би хэнтэй ч уулздаггүй”.

Дарга ширээн дотроосоо нэг цаас гаргаж ирээд, манай найзынд ирж байсан хүмүүсийн нэрийг уншиж. “Та энэ хүмүүстэй уулзаж байсан уу?” – “Уулзаж байсан, тэд нар манайд хоёр удаа ирсэн”. – “Тэгээд юун тухай ярьцгаав даа?” – “Гойдын юм яриагүй ээ...” – “Сибирь, цөллөг энэ тэрээ дурсацгааж байв уу?” – “Дурсацгаасан” – “Улс төрийн тухай ярьцгаасан уу?” – “Би улс төрөөс гадна байгаа, физик, математикаар хичээллэж байна”.

Дарга өөр нэг цаас гаргаад: “Нэг хүн ингэж ярьсан байна” гээд нэг балайгийн ярьж байсан юмыг яг үг үсэг алдалгүй уншиж өгчээ. “Тэр ингэж ярьсан уу?” Хаашаа зайлах вэ дээ? “Ярьсан”. – “Та яаж хандсан бол?” – “Би чагнаагүй, хичээлээ хийж байсан”. “Өршөөж хайрла, таны дэргэд зөвлөлтийн эсрэг юм ярьж байхад та чагнахгүй байж гэнэ. Үгүй шүү дээ, та чагнаж байсан, тэгээгүй бол миний уншиж өгснийг та нотлохгүй байх байсан”.

Манай найз дуугарсангүй, үгүй гэхийн газар алга. Ирэгсэдийн дотор мэдээлэгч байсан нь тодорхой, магадгүй нэг ч биш байх. Гэтэл дарга шахаж байна: “Та дуугүй байна уу? Таны өмнөөс би хариулья. Та намын гишүүнчлэлээ сэргээж, намыг дотроос дэлбэлэхийн тулд бууж өгсөн. Та троцкист нууц бүлгийг толгойлон гэртээ цуглуулж байсан. Таныг болон танай бүлгийнхнийг баривчилж шүүхэд өгөх бүхий л үндэс бидэнд байна”.

Найз маань: “Би ямар ч троцкист үйл ажиллагаа явуулаагүй, ямар ч ярианд оролцоогүй. Харин хов хүргэнэ гэдэг бол миний ёс суртахууны үнэмшилтэй таарахгүй. Тэднийг анх ирэхэд нь гэртээ оруулахаас шууд татгалзаагүй нь миний буруу болж” гэж хариулж.

Гэтэл нөгөө дарга өөрийнхөөрөө мугуйдалж гэнэ: “Бид таныг, танай бүлгийнхнийг баривчлана. Гэм байсан учраас мөрдөн байцаалтаар бүгд гэмээ хүлээцгээнэ. Та “хувьсгалын эсэргүү байгууллага байгуулсан” гэдэг зүйл ангиар ялагдана, таван жилийн хорихоос цаазаар авах хүртэл ялтай. Амьдрахыг хүсч байгаа бол, гэр бүлээ аврахыг хүсч байгаа бол, яаж аврахаа бодоорой. Та намтай санал зөрөх зүйл байхгүй гэж ярьж байна, үүнийгээ нотолчих”. Ингэж хэлээд, хамтарч ажиллахыг манай найзад шулуухан санал болгож. “Татгалзвал хар толгойдоо гомдоорой”.

Миний найз, ийм саналыг, мэдээж, няцааж чадах байсан. Гэтэл тэгсэн бол түүнийг тэр дор нь баривчлаад, шоронд орох, шонд дүүжлүүлэх хоёр зэрэглээн дунд байна гэсэн үг болно. Найз маань тэр хоёрын алийг ч хүссэнгүй. Айсандаа тэгсэн хэрэг биш, мань эр бол зоригтой хүн, харин юуны төлөө үхэх ёстой юм бэ? гэсэн асуулт байж. Хэдэн солиотой юм дэргэд нь донгосч байсны төлөө үхэх хэрэг үү? Манай хүн тэдний төлөө үхэхийг хүссэнгүй, бас эхнэр, хүү хоёроо үхүүлэхийг хүссэнгүй. Үзэл санааны төлөө юу? Үзэл санаанаас нь жолоодогч нар нь урваад, газар сайгүй нүглээ наминчилцгааж яваа. Тийнхүү манай хүн үүрэг хүлээж гарын үсгээ зурсан. Гэхдээ ховчин болох бодолгүй, энэ байдлаас гарна гэж найдаж байсан, мэдэж байгаа биз...

Хажуугийн ширээнийхэн хооллож гүйцээд, нэг нь тооцоогоо хийхээр үлдэж, гурав нь босч, ширээний чөлөөнд зогтусцаав. Глеб дуугүй боллоо. Ресторанд нэг ч их олон хүн байсангүй. Дуучин хүүхэн нүдээ өлийлгөн, элгээ тэврэн гэншинэ: “Амьдралд учрал ганцхан удаа тохионо, алтан учиг заяагаар ганцхан удаа тасрана...” Гойдгүй дуулж байна, гэхдээ Саша цыганы хүүрнэл дуунд дуртай.

Тэдний ширээний хавьд зогсож байсан хүмүүс хувцасны өлгүүр рүү зүглэж, Глеб яриагаа үргэлжлүүлэв.

– Тэгээд Москва руу, хамгийн томчууд руу, нөхөр Сольц руу гарч өгч. Тийм нэрийг сонссон уу?

– Сонсохоор барах уу, бүр танина гээч. Сайн хүн байгаа юм.

– Тийм үү? Сайн хүн гэж үү? Чи илүү мэдэх байх л даа, ялдам минь. түүнийг чинь “намын жудаг” гэгцгээдэг байв даа. За тэр “жудаг” руу чинь манай хүн яваад хүрч. Сольц түүнийг хүлээж авсан гэж байгаа, бод доо. Найз маань түүнээс: намайг элсүүлж авах гээд байна, ингэхэд, нэг коммунист бусад коммунистынхаа талаар далдуур хов зөөнө гэдэг чинь намын ёс зүй, ёс суртахуунтай хэрхэн нийцэх сэн билээ? гэж асууж. Сольц ингэж хариулж байна гэнэ: “Тэр байгууллагынхан коммунист болгон дээр ирэхгүй, жишээ нь, над дээр ирж байгаагүй. Гэтэл тань дээр очсон байна, энэ бол таны хэрэг гэсэн үг, тэгэхээр та л өөрөө шийд дээ”.

– Сольц түүнд тэгж хариулсан юм уу?

– Найз маань л надад тэгж ярьсан. Тэр бол хэзээ ч үнэнийг л ярьдаг хүн.

Сольц үнэхээр тэгж албархлаа гэж үү дээ? Тоогүй хэрэг ээ. Өөрийнх нь ойд шал өөр Сольц хоногшин яваа билээ.

– Тэгээд, цаашаа юу болоов?

– Москвагаас, Сольцтой уулзсаныхаа дараа найз маань буцаж ирээд чиний сая сонссоныг надад ярьсан юм. Бид хоёр шөнөжин сууцгаасан, өөр ч өчнөөн юм ярьцгаасан. Зиновьев, Каменев, Радек гурвыг үзэн ядна, Бухарин, Рыков хоёрыг нялуун магтаалаараа Сталинд тусалж, өөрсдийнхөө цаазын тавцанд очих замыг засцгаасан гээд бас ад үзнэ. Троцкийг тэдэнтэй дүйхгүй том зүтгэлтэн гэж хэлсэн. түүний чиг шугам ч зөв — нэг оронд социализм байгуулж болохгүй, бүлэг, жигүүрийнхнийг чөлөөтэй ажиллуулах хэрэгтэй, энэ бол үзэл бодол, бодол санаа чөлөөтэй болох зам, тэгснээрээ ардчилал руу явах зам гэж байсан.

– Троцкийг тэгтлээ нэг их ардчилагч байсан гэж бодохгүй байна.

– Хөөе ялдам минь, би чамд найзаасаа дуулсныгаа л уламжилж байна. Мэдээж, хөрөнгөтний ардчилал биш, социалист, пролетарийн маягийн ардчилал, гэхдээ би бол энэ мэтийн учрыг олдоггүй хүн. Бүхэлдээ Троцкийг сайшааж, суут хүн, гэхдээ өөрийгөө түүхийн толинд тунгаан харж, шинэ Бонапарт болохыг хүсээгүй, тэгээд тоглоомондоо хожигдсон хүн, өөрийнх нь мэдэлд үнэнч арми нь байсан, аль хорин гурван онд тэр гурвыг – Сталин, Зиновьев, Каменев гурвыг баривчлаад, буудан хороож болох байсан гэж байсан.

– Буудан хороох ий?! Энэ чинь ямар гээчийн ардчилал билээ?

– Ялдам минь ээ! Манай оронд чинь бүх юм — ардчилал ч, диктатур ч — буудан хороох дээр л тогтож байгаа шүү дээ.

– Үгүй, чи чинь философич болж таарах нь ээ.

– Байгаа царай минь л энэ. Ер нь найз маань: бүх юм баларлаа, Октябрийн хувьсгал сөнөлөө, улс орон фашизм руу явж байна гэхчлэн мөн ч олон юм ярьсан даа. Бас өөрийнх нь амьдрал ч дууссан гэнэ. Зүгээр лекц уншиж байгаа юм шиг тайван байсан, нээрэн шүү! Тэгээд яс

шийдсэн бололтой, босоод ингэж хэлсэн: “Надад юу ч тохиолдож мэднэ, тийм учраас хорвоо дээр үгүйдээн ганц хүн миний жинхэнэ явдлыг мэдэж байгаасай гэж би хүсч байна. Тэр хүн нь чи. Бид хоёрын энэ яриаг цаг нь болтол чамайг хэнд ч хэлэхгүй гэж найдаж байна. Дуугай байж сур! Ойлгож байгаа биз, ялдам минь? “Дуугай байж сур” — алтан үг дээ.

Глеб гөлөр харцаар ширээг тойруулан хараад, сандлынхаа түшлэгийг налав.

– Хөөе, ялдам аа, чи бид хоёр чинь нэрийн баяр дээр байгаа мангарууд шиг яагаад суугаад байна аа? Дахиад зуу зууг балгачихъя, хичнээн хيام үлдсэнийг хараач, хаялтай нь биш дээ.

мань хүн архиа татчихаад хиамаа гүйцээж идэв.

– Би түүнтэй хоёр өдөр уулзсангүй, гуравдахь шөнө нь манай байрны хонхыг хангинуулж алдлаа. Тэгсэн чинь хэсгийн цагдаа, хашаачин хоёр зогсож байна. “Хувцсаа өмс, явж гэрч бол”. Намайг хажуугийн байр руу авчирч, түүний өрөө рүү оруулсан чинь тэнд нэгжлэг хийж байна. Найз маань алга, авгай нь жигтэйхэн сандарчихаж, хүүхэд нь жижигхэн орондоо унтаж байна. Өглөө болтол нэгжлэг хийсэн боловч юу ч олсонгүй, протоколд хэлбэрийг бодон хэдэн хуучин номыг бичлээ, эс тэгвэл шөнөжин нэгжсэний хэрэг юу сан бтлээ? Тэд нар яваад өглөө, би үлдээд, нөхөр чинь хаана байна гэж хүүхнээс асуулаа. Шоронд л байгаа даа гэж бодсон юм. Тэгтэл хүүхэн: “Тэр одоо шарил хадгалах газар байгаа” гэдэг байгаа. Товчдоо, тэр маань амиа хоролчихож, сургууль дээрээ хор идчихэж, хүлээж байгаад хүн амьтан гарч гүйцэхээр хор залгичихаж, ялдам минь. “Намын жудаг”, нөхөр Сольцтой ярилцаад, тэр жудгийнхаа дараа хор залгичихаж. Энэ намын жудаг ийм л юм байна! Улс өглөө ирсэн чинь мань хүн хичээлийн танхимд хэвтэж байж. Бид түүнийг Волковын оршуулгын газар эцэг эхийнх нь хажууд оршуулсан. Ингэхэд, чамд гэж хэлэхэд, ялдам минь, тэр маань зөв юм хийсэн: өнөө хүртэл амьд явсан бол түүнийг өдийд хоринтаа буудан хороогоод, гэр бүлийг нь ч бас хөнөөчихсөн байх байсан. Тэгүүлэхийн оронд хүн амиа хорлоо л биз, тэр ямар анхных нь юмуу, бас сүүлчийнх нь ч биш. Одоо гэр бүл нь мөрөөрөө байгаа, хүү нь сургуульд орчихсон. Харин түүний явдлыг, түүний зовсон түүхийг ганц би л мэдэж байгаа, цорын ганц би. Агуу хүн байсан даа, ялдам минь! Гэтэл амиа алдсан! Хэдэн доодохоосоо дор юмнууд донгосох дур нь хөдөлсний төлөө тэр шүү. Тэгэхээр чи одоо надад хэлээд аль, ийм юм болдог байхад би тэр Каневский мэтийн чалчигчдад яаж хандаж байх ёстой байна, ялдам минь? Тэр муу шоронд хийдэг, аягүй бол цаазаар авдаг үгийг миний дэргэд, чиний дэргэд, Лёнягийн дэргэд хэлж байх ямар эрхтэй юм бэ? Боловсролтойгоо харуулах гэж тэр үү? Тэрний боловсрол юу юм бэ, нохой долоо. түүний мэдэж байгаа юмыг би мартаад удаж байна. Миний найз хүртэл гарын үсэг зурж байсан байхад, би нэг муу Каневскийд яаж итгэх юм бэ? Тэр гарын үсэг архивт байж байгаа, зуун жилийн дараа олж уншаад, энэ ч бас мэдээлэгч байсан байна гэгцгээнэ. Гэтэл тэр маань амьдралдаа ганц удаа худал үг хэлж үзээгүй, дээд зэргийн шудрага, дээд зэргийн журамтай хүн байсан юм.

Глеб Саша руу бөхийв.

– Намайг хүний шаар гэж бодох вий гэсэндээ би энэ явдлыг чамд ярьж өгч байгаа юм. Бидний дунд манийг баллаж мэдэх алтан хошуут байлгахгүй гэсэндээ би Каневскийг эвтэйхэн зайлуулсан. Ингэхэд энэ ажлыг би биш, чи хийх ёстой байсан юм шүү.

– Яахаараа би билээ?

– Яагаад гэвэл чи тийм намтартай. Калининд жолоо мушгиж байх хооронд чинь тэдний боловсон хүчин, тэр яс арьс болсон яатуу Кирпичева чи жирийн нэгэн жолооч байтал, чиний тухай бөөн хавгаст хэрэг бүрдүүлчихсэн. Чамайг Калининаас хөөж явуулсан манай төрөлх ажилчин-тариачныхаа сэргийлэхэд л баярлалаа гэж хэл... Би тэр Каневскийг донгосоод эхэлхээр энэ Сашка яагаад дуугай байгаа юм бол гэж шууд бодсон. Тэрний ярьсан юмнаас болж биднийг тийш нь чирээд эхэлнэ гээд бод доо, ялдам минь... Ямар вэ? Лёня бид хоёр бол багачуул, баян хуурчид, гэтэл чи? Ял эдэлсэн хүн, тэгж харвал, нэг эсэргүүгийнхээ дэргэд нөгөө эсэргүү нь Троцкийн онолыг задлан ярьж байна. Энэ бол байгууллага! түүний гол хүн нь чи. Чамд наад зах нь хорих ял баталгаатай. Гэтэл чи түүнийг өрөвдөж, пээ, үмх талх ч үгүй, гудамжинд гаргачихлаа гэж гоншигонож байх юм. Миний найз ч бас ингэж хүн болгоныг өрөвддөг байсан юм... Би чамд нэг юм хэлье: чамайг тэгэхэд, Калининд, Людкатай хамт дарханыд ирэхэд чинь анх харангуугаа л шоронгоос гарсан залуу байна гэж шууд тааж мэдсэн.

– Чи таамхай хүн юм.

– Нүүрэн дээр чинь бичээстэй байсан, ноосон цамцнаас чинь, савхин гутлаас чинь илэрхий байсан, бүгд хамсраад илт гэх юмуу даа. Би, ялдам минь зураач шүү дээ, миний нүд бол дуран хараа, би чамайг шууд таньсан: хоригдол, гэхдээ ердийнх биш, миний талийгаач найз шиг энэ араатны амьдралд зохицоогүй сэхээтэн хоригдол гэж яг таньсан. Түүгээр ч барахгүй, чиний түүнтэй адилхан гэдэг жигтэйхэн, зүрх рүү хутга шаачих шиг л болсон. Тэр хүрэн халиун үстэй, чинийх хар, тэр чамаас арай биерхүү, тэглээ ч гэсэн та хоёр их төстэй, царайны чинь янз адилхан, та хоёр нэг үүлдрийнх, шудрага ёсыг хайцгаана, дэндүү эелдэг. Хэдий тийм ч, би тэгэхэд, Калининд, чамд шууд хайртай болсон, малынх шиг амьдралд маань дахиад жинхэнэ хүн гарч ирлээ гэж бодсон, гэхдээ тэр найз маань эелдэгээсээ болж баларсан, чамайг бол тэгэхгүй юм байна гэж дотуураа мэдэрсэн.

– Чамайг надаас түрүүлж балрах вий гэж санаа зовж байна гэж Саша өгүүлэв.

– Тийм үү? Яагаад тэрэв?

– Гурван сар орчмын өмнө чи Каневскийн тухай надад юу гэж хэллээ?

– Пушкины ойн тухай ярьж байл уу, санахгүй байна.

– Тэгвэл сануулья: Бид Каневскийгээс болж шоронд орно... Би дөрөөн дээрээ байх ёстой, хажууд минь хэн байгаа талаар бодож байх ёстой гэж хэлсэн. Чи тэгж хэлсэн үү?

– Ярьсан ч юм шиг.

– Тэгвэл яах гэж Каневскийг ресторанд очъё гэсэн юм? Яах гэж хажуудаа суулгасан юм? Яах гэж архиар шахсан юм? Тэр чинь бидэнтэй явах дургүй байсан шүү дээ.

– Үгүй яахав, нэг хамт олон, цалингаа цуг авцгаалаа, юм балгахаар явцгааж байна, тэгээд

түүнийг урихгүй бол эвгүй шүү дээ.

– Өө, эвгүй юү? Биднийг шоронд чангаагаад оруулчихаж магадгүйг нь мэдэж байгаа хүнээ ресторанд дагуулаад орж байдаг. Ингэж байгаа бол чи хэн юм бэ? Бас социализмын тухай, бас бус балай юмны тухай тэр биш, чи л эхэлж ярьсан. Тийм ярианд чи өдөж оруулсан, тэгээд мань хүн бодож байгаа юмаа хэлсэн. Чи түүнийг өдсөн. Яах гэж тэрэв?

Глеб түүн рүү эгцлэн харж,

– Чи нээрэнхээсээ ингэж хэлж байна уу? гэв.

– Нээрэнхээсээ байлгүй яахав. Хүнийг өдчихөөд, дараа нь Семён дээр: “Каневскийг хал, илүү дутуу юм бурж байна” гээд тавьж хүрсэн.

Глеб дал мөрөө хавчив.

– За яахав, чи намайг өдөөн хатгагч гэж үзэж байгаа бол...

Саша хундагатайгаа гүйцээж уугаад талхны зах үнэрлэв.

– Би чамайг өдөөн хатгагч гэж үзэж байсан бол энэ ширээний ард ганц минут ч цуг суухгүй байсан. Чи яагаад Каневскийг ресторанд дагуулж очсоныг чинь би чамд хэлье. түүний “их зан” чиний эгдүүг хүргэж байсан, өөрийгөө суут хүн болгон төсөөлж, онцгойрч байна, маниас сэжиглэж байна, тэгэхгүй шүү, “ялдам минь”, чи бол бидний өрөөсөн, тийм учраас биднээс түшиж бай, бид цалингаа угааж байна, чи ч бас угаа, бид архи ууж байна, чи ч бас уу, бид социализмын тухай марзганаж байна, чи ч бас марзгана гэх маягаар чи хандсан. Чи биеэ эзэмдэж чадахгүй байна, тийм учраас би: надаас өмнө балрана гэж хэлж байгаа юм.

– За яамай даа, намайг ховч гэж хэлэх нь л гэж саналаа шүү.

– Чиний найзын явдал эмгэнэлтэй, гунигтай түүх байна. Даанч түүнд гарах арга зам байсангүй. Би цөллөгт троцкийчуудыг харсан, айхгар хаттай хүмүүс. Тийм учраас л тэднийг үндсээр нь устгасан, одоо бол сулхан хүмүүс хэрэгтэй, тэднээр ямар ч баримал хийсэн болно. Бид өөрсдөөрөө дуртай баримал хийлгэхгүйн тулд биеэ барьж байх хэрэгтэй, сэрэмжтэй байх хэрэгтэй. Үнэгэн шогшоо бүжиглэж байх надад таатай байдаг гэж бодож байна уу? Миний хувьд энэ ажил юм уу? Гэвч би ёроолд, замган дотор хэвтэж байна, эр хүний хувьд нэг их шохоорохоор байр суурь биш, гэхдээ би ийм гутамшигт нөхцөлд ч шудрага чигээрээ байхыг хүсч байна, цаг нь ирж магадгүй, тэгвэл тэндээс гарч ирнэ. Гэтэл чи хөөсрөөд байна, энэ хөөсөөр чинь л чамайг илрүүлчихнэ. Семён маргааш тийшээ очоод: “Манай ажилтан Дубинин Каневскийг илүү дутуу юм бурж байна гэж надад илтгэлээ” гээд хэлчихнэ. Чамайг урьцгааж: “Глеб Васильевич, танд баярлалаа, та жинхэнэ зөвлөлтийн хүн шиг ажиллаж байна, хойшид яг тэгж байгаарай, бидэнд зөвлөлтийн эсрэг элдэв яриаг мэдээлж байгаарай” гэнэ. Тэгээд чи дэгээнд орох нь тэр. Хүнээр даажигнах гэсэн чинь өөрөө даажигнуулах чинь тэр болно.

Танхимын гэрэл бүдгэрэв.

– Гарах дохио өгч байна гээд Саша үйлчлэгчийг дуудаж тооцоо хийв.

– Би болсон явдлын тухайд харамсаж байна, чи яахыгаа санаснаараа шийднэ биз. Гэхдээ би бол чиний хүн шүү, Сашка!

– Тэрийг би мэднэ. За хөдлөө гээд Саша бослоо.

Варя Лена Будягинатай санамсаргүй таарав. Игорь Владимировичтой “Ударник” кинотеатрт “Балтийн депутат”-ыг үзээд гарахад, гадаа олон хүнтэй, хөл хөдөлгөөнтэй, дулаахан сайхан байв. Игорь Владимирович голын эргийн засмалаар жаахан алхахыг санал болгожээ. Тэр хоёр зүүн гар тийш эргэтэл, яг тэнд нүсэр том байшингийн нэг орцны дэргэд Лена Будягина байгааг Варя харжээ.

Лена орцны хаалгыг нээх зуураа, яагаад ч юм бэ, эргэж харахдаа царай нь хувьсхийгээд явчихсныг анзаараад, өөрийг нь таньсныг Варя ойлгожээ. Варя алчуураа бүр кинон дээр байхдаа авчихсан, шулуун хар үс нь хуучин янзаар захнаас нь даван унжиж, бас магнай дээрээ урьдын адил хөхөлтэй байсан болохоор түүнийг таньж ядах юмгүй байсан байх, харин Лена хуучин хүлхэгэр пальтотой, маажгий шаахайтай байсан, түүнээс гадна хугацаа ч өнгөрсөн... болохоор түүнийг танихад амаргүй байсан боловч Варя шууд таньсан аж. Хичнээн хугацаа өнгөрөө вэ? Сашаг баригдахаас өмнө хамтдаа шинэ жилийг угтаж байсан, тэгэхээр дөрвөн жил гаруй болчихож. Тэгэхэд Лена Юрка Шароктой хамт байсан, Шарок бүхний нүүрэн дээр Вика Марасевичийг улайн цайм эргүүлээд байснаас болж Нина хэрүүл уруул дэгдээсэн боловч Лена дуулгавартай гэгч нь Шароктой яваад өгөхөд Саша түүний араас “Үүнээс дор баас олсонгүй юү?!” гэх үг хаясан...

Лена дотогшоо орох уу, эсвэл Варя руу зүглэх үү гэдгээ мэдэхгүй, орцны онгорхой хаалганы дэргэд зогсознов. Ийм шийдэмгүй бус байдлыг Варя эдүгээ олон хүний царайнаас олж харах болсон, тэд нар хуучин найзууд нь өөрсөдтэй мэндлэх эсэх тухайд эргэлзэж байгаа юм.

Варя инээмсэглэн,

– Сайн байна уу, Лена! гээд гараа өгөв.

Ленагийн царайд яльгүй ичингүйрсэн мишээл илэрч, өөдөөс нь духайсхийн харахуйд, энэхүү мишээл, энэхүү харцыг үзээд, Варя түүнийг сүүлчийн удаа шинэ жилээр биш, Старопименовскийн хөндлөн гудманд, Урлагийн ажилтны клубт харснаа санав. Тэгэхэд Варя Костятай, Лена Шарок, Вадим Марасевич хоёртой цуг очсон байсан, яг ингэж инээмсэглэж, яг ингэж духайсхийн харж байсан. Бүх хүн нүд алдсан сайхан хүүхэн байсан даа.

– Сайн байна уу, Варя хэмээн Лена түүн рүү дөхөж гар бариад, – Тантай уулзаж байгаадаа баяртай байна. Аж амьдрал ямаршуухан байна, Нина яажшуухан байна? гэв.

– Миний бүх юм дажгүй, ажил хийж байгаа, ингэхэд, та танилц, миний дарга... Игорь Владимирович... Лена...

“Будягина” гэж Варя нэмж тодруулсангүй. Тэр овгийг хэлэхээсээ айсандаа биш, Лена одоо энэ овогтойгоо байгаа эсэхийг мэдэхгүй байсны учир тэгжээ.

– Нина маань одоо их хол байгаа, бараг жилийн өмнө хүнтэй суусан.

– Мэдээ сураг ч үгүй, үзэгдэж харагдах ч үгүй болохоор нь Нинаг хаачсан юм бол гэж бодоод

байлаа.

– Та энд суудаг юмуу? хэмээн Варя үгийг нь таслан Нинагийн тухай асуудлыг займчуулав. Нина Макстай байгааг хэн ч мэдэх ёсгүй.

– Тийм, хүүтэйгээ, дүүтэйгээ...

Эхийнхээ тухай огт дурссангүй, тэгэхээр эцгийг нь төдийгүй эхийг нь бас шоронд хийчихсэн байх нь.

Лена гараа өгч,

– Би таныг саатуулж байна. Нинад захиа бичвэл миний мэндийг уламжлаарай гэв.

– Би тань дээр нэг ирж болох сон болов уу?

Лена түүн рүү гайхшран духайж харснаа,

– Тэгээрэй л дээ гэв.

– Та утсаа өгчих. Би утасдаж байгаад ирье.

Лена толгой сэгсрэв.

– Манайд аль хэзээний утас байхгүй.

– Танайх энэ орцонд юмуу?

– Тийм, нэгдүгээр давхар, баруун гар талын байр, гурав хонхдоно. Өглөөнөөс дөрвөн цаг хүртэл би гэртээ бараг байдаг юм.

– Та ажил хийхгүй байна уу?

– Одоохондоо үгүй, нарийндаа бол аль хэзээний үгүй.

– Тантай уулзсанаа би Нинад бичнэ, ойрын хэд хоногт танайд ирнэ ээ, та дургүйцэхгүй биз дээ?

– Миний одоогийн байдлыг бодолцвол та манайд ирэх хэрэггүй ч байж магадгүй.

– Би таны байдлыг мэднэ. Тэглээ гээд юу гэж?! Бид эртний танилууд, нэг сургуульд сурч байлаа, би танайд орох эрхгүй гэж үү? хэмээн Варя үсээ сэжив.

– За яахав, ирвэл баяртай байх болно.

Варя, Игорь Владимирович хоёр эргийн засмал даган алхав.

Варя түүн рүү харснаа,

– Тэснэ шүү, Игорь Владимирович! гэв.

– Тэсч байна!

– Тун сая хэнтэй танилцсанаа та одоо мэдэх болно.

– Би аль хэдийн гадарлачихсан. Баригдсан хүний гэр бүл.

– Гэхдээ баригдсан хүн нь хэн гээч! Бу-дя-гин. Иван Григорьевич. Ийм овгийг та мэдэх үү?

– Мэднэ. Оржоникизегийн орлогч байсан. түүнээс өмнө элчин сайд байсан.

– Ноднин баригдсан. Буудан хороосон. Лена “хүү, дүү хоёртойгоо байдаг” гэж хэлсэн. Тэгэхээр эхийг нь ч бас буудан хороосон гэсэн үг, бас большевик байсан юм.

– Тэр таныг нэг их урихгүй байх шиг сэтгэгдэл надад төрсөн гэж Игорь Владимирович хулгасхийн өгүүлэв.

– Яг тэгсэн. түүний ойлголтоор бол тэднийд очих нь зохисгүй.

Игорь Владимирович уул нь “Таны ойлголтоор бол?” гэж асуух ёстой байсан байх. Гэтэл тийм асуулт “Танд түүн дээр очиж байхын хэрэг байхгүй” гэсэн зөвлөгөө агуулж таарна. Тийм учраас тэрээр дуугүй байсан нь дээр гэж шийджээ.

“Тагнуул, хорлон сүйтгэгчид, алуурчдыг” буруушаадаг хурал цуглаанд Варя оролцохгүй. Оройн ангид сурдаг болохоор сургууль руугаа яваад өгнө, ажлын цагаар бол Моссовет юмуу, Мосстрой руу явчихна, үнэхээр тийш нь явуулсныгаа Игорь Владимирович нотолчихно. Хурал цуглаан болох гэж байгааг яаж мэддэг нь даргынх нь хувьд оньсого чигээрээ үлдэж. Нэг удаа цуглаан болох гэж байгааг мэдэлгүй гэнэдсэн учир тэрээр хаалга руу зүглэх зуур: “Игорь Владимирович, би АПУ (Архитектур-төлөвлөлтийн газар) руу явлаа шүү!” гэж. Цаадах нь: “Өө, тэгэлгүй яахав, шуурхайлна шүү, Иванова, тэд нар таныг хүлээж байгаа” гэж хариулжээ. Хөндлөнгөөс харахад бүх юм ёсоороо буй мэт үнэмшилтэй байж. Варя түүнийг тусыг олзуурхан бодсоноо, үүдэнд зогтусан эргэж зэрвэс хараад толгой дохьжээ.

Дарга өрөөндөө буцаж ороод түүний гудамж яаж гарахыг харах санаатай цонх руу очив. Яалтай ч гэхэв, тэрээр энэ бүсгүйд хайртай, бүр аль хэзээнээс, “Национал”-д анх танилцсан яг тэр мөчөөс хойш сэтгэл алдарч яваа билээ. Тийшээ Викатай очсон байсан нь Варягийн хувьд жаахан тиймэрхүү зүйл, гэхдээ түүнийг өргөн хүрээтэй бүрх малгайгаа авахад нүдийг нь хармагцаа хэнтэй цуг яваа нь ямар ч падгүй хэрэг гэдгийг мань хүн ойлгосон. Падтай ганцхан юм нь яаж хамтдаа гарч явах вэ л гэдэг асуудал болж. Гэвч тэгсхийгээд бүсгүйн бараа тасарсан, Вика түүнийг нэг билъярдчин гректэй суусан, тэр гэрлэлт нь бүтэл муутай болж таарсан гэж ярьж байсан. Тэгээд нэг өдөр Левочка Варяг тэдний зураг төслийн товчоонд зурагчнаар оруулахаар дагуулж ирэхэд нь Игорь Владимирович энэ явдлыг хувь заяаны бэлэг гэж үзсэн сэн.

Хайр сэтгэлтэйг нь мэдэж байг гэсэндээ тэрээр хоёр жилийн өмнө зүрхлэн шийдэж бүсгүйд

нэг захиа явуулсан. Маргааш нь мань хүүхэн өрөөнд нь ханцуйгүй даашинзтай орж ирээд үүдэнд зогссонд, түүнийг суу гэхдээ наранд сайхан шарагдсаныг нь бас хэлжээ.

– Би гол дээр, Серебряный бор-д нарласан юм. Тэр ч яахав, би таны захидлын тухайд хэлэх гэж явна гээд Варя чимээгүй байзнаснаа, өөр хүнд хайртай, тэр нь алс хол яваа, жилийн дараа ирнэ, түүнийгээ хүлээж байгаа гэж хэлжээ. Тэгэхэд мань хүн хүчлэн инээмсэглээд: “За яахав, Варенька минь, би ч бас хүлээе” гэсэн билээ.

Бүсгүйн хайрт нь ямар гээчийн хүн болохыг мэдэх нь түүнд мэдээж сонин байлгүй яахав. Варягаас энэ тухай шууд биечлэн асуух боломжгүй гэж үзэж. Гэхдээ Викагийн ярьсан зүйлээс, бас Левочкагийн ганц нэг үгнээс тэр хүн нь явж явж Варягийн эгчийн нэг ангийн найз бололтой, Сибирьт цөллөгт байгаа, Варя ээжийнх нь нэг өрөөг билъярдчин нөхөртэйгөө хамт хөлсөлж байсан гэж ойлгожээ. Гэтэл хоёр жил өнгөрчихөөд, гурав дахь нь дуусах гэж байхад Варягийн амьдралд ямар ч өөрчлөлт гарсангүй. Үүнээс үндэслэн Игорь Владимирович нөгөө цөллөгийнх нь хүний л нэг юм болохгүй байгаа хэрэг гэсэн дүгнэлт хийсэн аж. тэрээр Варягийн гутарч явааг мэдээд байв: амралтаа ч авдаггүй, нэг юм хүлээгээд Москвад хоргодоод байдаг. Ийм байдалд мань хүний горьдлого бүтэж магадгүй мэт боловч яаравчлан дүгнэлт хийхээс эмээж, бүх юм одоогийнхоороо байг гэж боджээ: тэр хоёр цуг ажиллаж байна, түүнийг өдөр болгон харж байна, энэ бүхэнгүйгээр амьдрах арга алга, гагцхүү үүнээс дордчихгүй, энэ л байдлаараа байгаасай, амаргүй цаг үе шүү дээ, гэтэл Варя болгоомжгүй аяглаад байхыг яана.

Варя баярын жагсаалыг үл тоодог нь хамгаас илүү санаа зовооно. Өглөөний ес гэхэд бүх ажилтан зохих байрандаа цуглачихна, цөмөөрөө гоёлын хувцастай, эгнээ эгнээгээрээ жагсан, уриа лоозун, цэцэг навчтай Улаан талбайгаар алхалж байхад ганцхан Иванова л байхгүй. Ингэж болохгүй гэж мань дарга нэг удаа түүнд ойлгуулсан. Амьтны дургүй хүргэхийн хэрэг юу байна? Ийм юм хүний нүдэнд шууд тусна. Гэтэл Варя сургуулийнхантайгаа хамт жагсдаг, тийм шалтаг үнэмшилтэй биш гэж үү? гэж хариулсан.

– Биш, оройн сургуулийнхан жагсдаггүй юм гэж мань хүн тэгэхэд хэлсэн.

Энэхэн зуур хал балгүй, гайгүй шүү өнгөрөөд байгааг ажлын газрынхнаас нь өөрөөс нь өөр хэн ч түүнийг царайлагаас цаашгүй нэг муу зурагчин хүүхэн гээд төдийлөн тоодоггүйгээс улбаатайг Игорь Владимирович ойлгож буй. Харж хянаж байх ёстой хүмүүс нь манай үед ямар нэгэн санал үл нийлэх явдал хэрхэвч байх ёсгүй гэсэн санаандаа баригдчихсан хэрэг. Нэг муу жулдрай бүсгүй битгий хэл дэлхийд нэр цуутай хүмүүс ч номхон хөшчихөж байгаа юм чинь. Нэг хоёр удаа цуглаанаас яваа л биз, мэдээж ёс бус зүйл, гэхдээ оройн сургуульд сурч байгаа хүн, албан ёсны магадлагаа ч бий. түүнээс гадна Иванова элдвээр дүвчигнэхгүй. Ажил дээрээ нэг ч илүү дутуу юм ярихгүй. Даргатайгаа хоёулхнаа байх юм бол доогтой инээнэ, бухимдана, хорон үг хэлнэ.

– Та яагаад дуугүй байна, Игорь Владимирович?

– Өө зүгээр, нэг юм бодоод л.

– Таны юу бодож байгааг би мэднэ. “Тэснэ шүү, Игорь Владимирович” гэж хэлсэн маань

таалагдсангүй. Одоо чинь хүн болгон юм болгоноос айдаг болохоор, би таныг нэг чимхээд авах гэсэн юм шиг санагдсан байх, харин би бол энэ мэтийг зөвхөн тэнцвэржүүлэх зорилгоор л тэгдэг юм. Левочка, Ирина хоёр бол таныг шүтэж мөргөөд л байна: “А-яа-яа, манай Игорь Владимирович ёстой гоё эр, а-яа-яа, манай Игорь Владимирович суут ухаантан, манай хүн бол Москваг өөрчлөн байгуулах асуудлаар Сталины гол зөвлөх...” Би бас дуу хоолойгоо нийлүүлчих юм бол та чинь бурхан болж хувирна.

– Та мөн сайхан онож хариулна шүү.

– Та юуг хэлж байна?

мань хүн өөрөө санаандгүй гэрч болж таарсан, саяхны гуанзанд болсон явдлыг хэлж байгаа юм байж. Ажилтан, албан хаагчид голдуу бүлэг бүлгээрээ хоолонд орно, тэр зуураа хүний өмссөн зүүсэн, суусан салсанаас авахуулаад элдвийг бурцгаахын хамт хамгаас түрүүнд, мэдээж, сонины мэдээ, шүүх хурал энэ тэрийг ярьцгаана. Яллагдагчдын өдүүлсэн гэмт хэргийг бүгдээрээ бухимдан шүүмжилж байхад ганцхан Варя л хоолоо чимээгүй идэж сууна.

– Иванова, чи юу бодоов, санал нийлэхгүй байгаа юм уу, хаашаа юм?

Энэ асуултыг Костоломов гэгч үнэнхүү нүдэнд хүйтэн этгээд тавьжээ. Тэр бол боловсон хүчний хэлтсээс тэдний товчоонд саяхан томилсон шинэ зурагчин. Игорь Владимирович түүнийг ажлын ямар ч туршлага байхгүй, товчоонд зурагчин хүрэлцээтэй байгаа гээд авах дургүй байсан боловч боловсон хүчний хэлтэс тулган өгсөн юмсанж. Игорь Владимирович энэ талаар бүр найз нартайгаа зөвөлсөн гэж байгаа. Цаадуул нь: “Чи тархиа бүү зовоо. Боловсон хүчний хэлтэс өөрсдөө чам руу хүн явуулж байгаа бол танай товчоонд нууц ажилтан дутаж байгаа гэсэн үг” гэгцгээжээ.

Варя Костоломов руу хараад,

– Та нарын ярьж байгаа юмыг сонсоо ч үгүй. Орой математикаар шалгалтын ажилтай, тоогоо толгойдоо бодож сууна гэжээ.

Варя тэр явдлыг саналгүй яахав.

– Тэр муу новшид хариу өгөх гэж намайг ам нээхэд таны царай бүр цонхийгоод яьчихсан шүү, Игорь Владимирович. Та дэмий санаа зовж байх юм, би чинь насанд хүрсэн хүн шүү дээ.

– Та насанд хүрсэн хүн, гэхдээ тэр болгон болгоожтой байж чаддаггүй л дээ.

– Тэр яагаад тийм овогтой байгаа юм бол, та юу гэж бодож байна? Өвөг дээдэс нь Малюта Скуратовт үйлчилж байсан юм биш байгаа? Аягүй бол яс үйрүүлэхдээ аврагууд байсан биз.

– Тийм ч байж болно. Гэхдээ түүний өвөг дээдэс оточ домч нар, яс барьдаг хүмүүс байсан, тэгээд Костоломов болсон байж ч болно.

Тэр хоёр Зубовын талбайн зүг Крымын гүүрээр гарч явав. Бүрэнхийд гүүрний ган татлаганууд бараантан харагдана.

– Би тухайн үедээ дээгүүр нь дэнлүүн сондор татахыг санал болгосон юм. Тэгсэн бол гүүр ч, Москва гол ч сэргээд явчихгүй юу. Цахилгаан хүрэлцэхгүй гээд зөвшөөрөөгүй юм. Тэр санаа толгойноос салахгүй байсныг хэлэх үү, яг тэр үеэр Нью-Йорк орж таарлаа, тэндхийн олон гүүр шөнийн цагаар гэрэл гэгээнд умбаад, тийм болохоор хөнгөхөн, агаарт байгаа юм шиг харагдана. Ямар гоё гээч. Хараад дэмий л атаархаж явлаа.

– Бид тэрийг чинь хэзээ ч үзэхгүй хэмээн Варя санаа алдаж, – Гэтэл Энэтхэг рүү, Африк руу явах юм сан гэхээс яаж хорхой хүрнэ гээч. Даанч энэ бол Марс руу нисэхийг мөрөөдсөнтэй нэг үг. Бид чинь хамжлагынхан юм чинь, эзэн маань тосгоноосоо цааш явуулна гэж заяа нь байхгүй.

Зөвлөлтийн гэр бүлд өсч бойжсон, зөвлөлтийн сургуулиар хүмүүжсэн энэ охин яагаад ингэтлээ эвлэршгүй үзэлтэй байна? гэж Игорь Владимирович байнга гайхна. Бүх юм муу, бүх юм муухай, бүх юм шудрага биш. Бүх юмыг дээд зэргээр байлгах залуу насны дэвэргэн үзэл үү? Сургуулиа төгсөнө, өөрийгөө харуулж чадах сонирхолтой ажил олоход нь түүнд туслана, энэ бол их чадварлаг, тэр ч бүү хэл, авьяаслаг охин, тэгээд энэ л чухам амьдралын гол зүйл гэдгийг ойлгоно.

Тэр хоёр Арбатад байдаг Варягийн байр руу дөхөж ирэх үед Игорь Владимирович,

– Таны танил бүсгүй чинь ямар мэрэгжилтэй юм бэ? гэж асуув.

– Мэдэхгүй. Та яах гэв?

– Хаа ч ажилладаггүй юм байна, бодвол ажилд орж чадахгүй байгаа байх.

– Та түүнийг хоёр жилийн өмнө харсан болоосой. түүнээс гоё хүүхэн Москвад байгаагүй гэж бодож байна. Яаж хувцаслана гээч, гадаадад удаан суусан болоод. Гэтэл одоо маажгий шаахайтай, хүний пальтотой явж байна. Хамаг юмаа зарчихсан байх. Хүү, дүү хоёроо тэжээх хэрэгтэй байгаа.

– Юу чаддагийг мэдчихээрэй. Би туслахыг хичээе.

Варя түүн рүү харав. түүний харцанд ердийн нөхөрсөг сонирхлоос гадна өөр ямар нэг юм байгааг тэрээр анх удаа олж харжээ.

Шарок буцаж ирэх шийдвэр Москвагаас аваад бодол болов.

Слуцкийг Узбекистан руу явж байгаатай холбогдуулан хоёрдугаар сарын арван долоонд Ежовын дотроонд хүлээн авалт болжээ. Слуцкий тэр шөнөө үхсэн байна. Хэдийгээр “Правда” сонинд товчхон ч гэсэн халуун дотно үгтэй эмгэнэлийн мэдээ гарсан хэдий ч тэр мэдээ Шарокийг яахин хуурах билээ. Москва бол Парис биш, тэнд арав хоногийн үйлчилгээтэй эм хэрэггүй, ганц өдрийнх ч болно. Бас Шпигельглас алга болж оронд нь Павел Анатольевич Судоплатов гэдэг шинэ хүн болжээ.

Слуцкийд өөр зам байгаагүй. Гэтэл Шпигельгласыг бас шоронд хийсэн учраас энэ явдал Лев Седовыг алсантай холбоотой гэдгийг Шарок ойлгож байв. Седов үхсэнээр Зборовский Троцкийн захидал харилцаанд төдийгүй түүний ойр дотныхны хүрээлэл рүү нэвтрэх боломжоо алдсан. Серебрянскийг өөрийг нь ч, түүний бүх ажилтан залуусыг ч, тэдгээрийн дотор “Алексей”-г ч шоронд хийчихсэн. Нөгөө францаар сайн ярьдаг боксчин чинь тэр.

Шпигельглас тушаал буулгаж, эмийг “Алексей” дамжуулж, Зборовский ажил явдлыг амжуулсан. мань Шарок үүнд ямар ч хамаа байхгүй, бүтэл муутай ажилбар болсон гэж бодож байгаа. Гэхдээ Шарок өөрийнхөө байгууллагыг мэднэ. Тэнд ямар ч үндэслэл, нотолгоо нэмэр болохгүй. “Хэлтсийг Шпигельгласын хүмүүсээс цэвэрлэх” хэрэгтэй гэсэн бол ёстой сайхан цэвэрлэнэ, буудаж хороогоод л дашийн шог болох нь тэр.

Одоо яахав, яавал таарах вэ? Очихгүй алга болчих уу? Хаашаа? Орогнол гуйж “үл буцагч” болох уу? Олохдоо л нэг олно. Игнатий Райссыг олоод, алчихсан шиг л. Нөгөө талаас өөрийг нь Шпигельгласын хүн гэж хэрхэвч болохгүй. түүнийг Ежов өөрөө Шпигельглас руу явуулсан. Хэрэгцээ гарвал орлуулахаар явуулсан байж ч магадгүй. Чухамхүү тэгэх гэж дуудаж байж ч болно. Тэгэхэд: “Сайн ажиглаж ав” гэж хэлсэн шүү дээ.

Гэтэл Ежовыг Усан тээврийн ардын комиссараар хавсарган томилсон. Хачинаас хачин томилгоо. Усан тээвэр! Гол мөрний тээвэр — энэ хэнд хэрэгтэй юм бэ?! Ягодаг ч шууд буудчихаагүй, Холбооны ардын комиссараар бас томилсон, тэгж байгаад дараа нь шоронд хийсэн. Гэхдээ тэгэхэд Ягодаг ДЯАК-аас шууд халсан, харин Ежовыг халсангүй, мань Шарок бол түүний хүн, нэмэрт нь энэ элдвийн Слуцкий, Шпигельглас энэ тэр шиг муусайн польш юм уу, еврей биш, орос хүн. Юу л болвол болог, явах хэрэгтэй!

Шарокийн бодож байсанчлан түүнтэй Седовын асуудлаар ярилцжээ. Байцаагаагүй, зүгээр л ярилцаж. Тайлбар бичиж өгөхийг хүссэн дагуу Шарок юу болсон, ясныг бичиж өгөв. Ингэхэд яасан билээ? Седовын бие муудсан, Шпигельглас “Алексей”-г ирүүлсэн, түүнийг Зборовскийтэй уулзуул, гэхдээ уулзалтад өөрөө битгий байлц гэж тушаасан. Уулзуулсан. Байлцаагүй. Тэгээд арав хоногийн дараа Седов үхсэн. Тэгээд л тэр. Шарок удаан бодсоны эцэст, “Седовын үхэл ‘Тюльпаны’ ач холбогдлыг маш чухал мэдээллийн эх сурвалжийнх нь хувьд ихээхэн үнэгүйдүүлж, түүнийг Л. Д. Троцкийн хүрээлэл рүү нэвтрэх боломжгүй болгосон” гэж нэмж бичжээ.

Тайлбар бичгээ гардуулж өгснөөр хүлээх өдрүүд дахиад урсаж эхлэв. Хэлтэстээ дэмий

холхино. Павел Анатольевич Судоплатовтой танилцаж, түүнд Третьяков, Зборовский хоёрын тухай ярьж өгөв. Судоплатов тэдний тухай хамаг юмыг мэдээж мэдэлгүй яахав, гэхдээ шилэн аяганаас халуун цай оочлох зуур анхааралтай сонсжээ. Шинэ дарга нь ханиадтай, бие нь бүлээнтэй, нүд нь нулимстан, хамар нь улайгаад, царай нь гойдгүй байсан хэдий ч Шарокт лут сэтгэгдэл төрүүлсэн аж — хүйтэн царайтай, өрөвч сэтгэлгүй, жинхэнэ тагнуул. Парист болох троцкист IV Интернационалыг зохион байгуулах хурлын бэлтгэлийн талаар Зборовскийгээс ирж байгаа мэдээлэлтэй одоохондоо танилцаж байхыг тушаажээ.

Долдугаар сарын 20-нд Ежовын орлогч бөгөөд Улсын аюулгүй байдлын ерөнхий газрын даргаар Лаврентий Павлович Берияг томилв. Ежовын хоногийн тоо гүйцэж, түүний оронд Сталины ойрын хүн Берия ирж байгаа нь хэн бүхэнд тодорхой болов. Шарок хамаг найдлагаа Ежовт тавьж байсан болохоор улам түгшүүрлээд эхлэв. Одоо яах вэ? Зүүгдэх хүн нэг ч алга, тусламж гуйх хүн ч бас алга, Молчанов, Вутковский, Штейн, Дьяков энэ тэрийг бүгдийг нь шоронд хийчихсэн болохоор ганц танил царай ч алга. Тэдэнтэй, ял авсан ардын дайснуудтай хамт ажиллаж байснаа дурдах хүртэл аюултай.

Үлдсэн цорын ганц хуучин танил нь Виктор Семёнович Абакумов. Тэр одоо том зиндаанд яваа — Ардын комиссариатын хамгийн томоохонд ордог Ростовын мужийн ДЯАК-ын газрын дарга. Уул нь тэдний хэлтэст хэрэг үдэгч байсан билээ. Ежовыг ирснээр дэвшээд эхэлсэн. Албан өрөөндөө хураагдсан номтой баахан шүүтээ тавьсан, амьдралдаа тэдгээрийн нэгийг нь ч уншаагүй байх л даа. Харанхуй бүдүүлэг, боловсрол байхгүй, хүүхний донтой, хараалын эзэн, фокстротын хорхойтой, харваас ердөө л баавгай атлаа өөрийгөө агуу бүжигчин гэж гайхуулна. Тэгэхэд нэг удаа Шарок өмөөрөөгүй бол мань хүн өдийд умард нутгийн жаварт хаа нэгтээ хорих ангийн ахлах төлөөлөгч хийгээд шуухитнаж явах байсан бий. Тэр тухай сануулж болохгүй: би өөрийн авьяас чадвараар биш, Ленин-Сталины үйл хэрэгт чин үнэчийнхээ хувьд биш, чам шиг муу баасны ачаар ийм яваа хэрэг үү гээд гомдчихно! Шинэ дайсантай л болохоос цаашгүй. Ачлаж явснаа сануулахад хүмүүс дургүй. Абакумов тэр үеийг ерөөсөө нэхэн санах дургүй ч байж магадгүй. Чухамхүү мань хүн л хэлтсийнхээ хуучин дарга нарыг байцаасан шүү дээ. түүнээс холхон байсан нь дээр. Абакумов байсхийгээд л Москвад ирдэг боловч Шарок түүнтэй уулзах гэж оролдохгүй. Гэтэл гудаанд санаандгүй таарчихжээ. Абакумов бөөн сүр явж байж, том дарга нарт нэг тийм онцлог бий. Хашгачиж гуугачаад байхгүй, тас няс, түр тархийгээд, дэвсчээд байгаа юм байхгүй, тэгсэн хэрнээ дарга явж байгаа нь андашгүй, хэнд ч зам тавьж өгөхгүй, гудааны голоор танк шиг чигээрээ дайраад, таних танихгүй хамаагүй хэн ч байсан толгой дохиж, харуулын хажуугаар мөн толгой дохин өнгөрнө, цаадуул нь ч түүнийг зүсээр нь таних учир үнэмлэх бичиг шаардахгүй.

тэрээр дэргэдүүр нь өнгөрөхдөө Шарок руу ч бас толгой дохисноо, тэр дорхноо зогтусчээ.

– Юра, энэ чинь чи юү?

– Би, Виктор Семёнович.

– Уулзахад таатай байна. Чи чинь тэнд шиг билээ?.. гээд Абакумов хилийн чанд руу зааж байгаа мэт толгойгоороо хажуу тийш дохив.

– Тэнд шиг ч юм шиг.

– Үлдэх үү, эсвэл буцах уу?

– Яг хэлж мэдэхгүй байна, Виктор Семёнович, манай ажил чинь өнөөдөр энд, маргааш тэнд... шүү дээ гээд Шарок бас хилийн чанад руу заах мэт толгойгоороо хажуу тийш дохив.

Абакумов хүнгэнүүлэн инээд алдав.

– Бидний комсомолд байхдаа: “Далай тэнгисээр, давалгаан дээгүүр, өдгөө энд, маргааш тэнд”... гэж дуулдаг шиг л гэснээ – Гэрэлсэн үү? гэж санамсаргүй асуув.

– Хараахан үгүй.

– Хөндлөнгийн үйлчилгээгээр байна уу?

– Тэгэх л болох юм.

– Хүүш, чи чинь тусдаа байртай шүү дээ, шинэ байранд орсныг чинь угааж байсан санагдана.

– Тийм, нөгөө л байр маань байгаа.

– Инээдмийн жүжиг, драмын жүжиг, эмгэнэлт жүжиг гурвын ялгааг мэдэх үү?

– За, инээдмийн жүжиг гэдэг бол... хэмээн Шарок эхэлтэл Абакумов үгийг нь тасдав.

– Байз, би өөрөө чамд тайлбарлаж өгье: “юугаар” гэдэг нь байгаа, “хэнийг” гэдэг нь байгаа, гэхдээ “хаана” гэдэг нь байхгүй бол энэ инээдмийн жүжиг; “юугаар” гэдэг нь байгаа, “хаана” гэдэг нь байгаа, гэхдээ “хэнийг” гэдэг нь байхгүй бол энэ драмын жүжиг; харин “хаана” гэдэг нь байгаа, “хэнийг” гэдэг нь байгаа, гэхдээ “юугаар” гэдэг нь байхгүй бол энэ эмгэнэлт жүжиг.

Тэгээд дахин хүнгэнүүлэн инээд алдав.

– Намайг ойлгов уу? Байдаснууд байгаа биз дээ?

– Байдасгүй газар гэж байх биш.

– За хө, маргааш орой, есөн цагт яая. Чи ирц бүрдүүл, би тэжээл аваад очье. Харин хаягаа өг, мартагнасан шиг байна.

Шарок хаягаа бичиж өгөөд, “тэжээлээс” татгалзав:

– Юу ч хэрэггүй ээ, Виктор Семёнович, манайд бүх юм байгаа.

Энэ арга хэмжээ Шарокт зарим найдвар төрүүлэв. Абакумов тэдний гэрт хүүхэнтэй хоноё гэж байгаа бол Шарок мөрөөрөө байгаа гэсэн үг. Абакумов хэнтэй хөлчүүрхэх, хэнтэй тэгж болохгүйгээ мэднэ. Ежов дууссаныг мэдэж байгаа хэрнээ итгэлтэй байгаа юм чинь нөгөө талаас дэмжлэгтэй гэсэн үг.

Шарок Каляд утасдаж, маргааш найзтайгаа ирэхийг тушаагаад,

– Худлаа маягладаг юм л хэрэггүй шүү, ойлгов уу?! Том хүнд хэрэгтэйг бодоорой! Тэр хүнээс миний хувьд их юм хамаарна гэж анхааруулав.

Каля бүх юмыг ёсоор болгохоо амлав. Энэ хүн нь Шарокийг Москвад үлдэхэд нь туслах байх, тэгвэл Юра өөртэй нь сууна гэж бодож л дээ. Мэдээж тэнэг толгой, гэхдээ дажгүй хүүхэн, өөриймсөг, үнэнч хүүхэн.

Маргааш нь Шарокийн бие, сэтгэл арай л хөнгөн шингэн байв. Троцкист IV Интернационалийн болох гэж байгаа их хурлын талаарх Зборовскийн мэдээллээр нэгдсэн мэдээ хийлээ. Их хурлыг Лозаннд болно гэж албан ёсоор зарласан боловч үнэн хэрэгтээ бол Парисын хаяа дүүрэгт, Троцкийн найз Росмерийнхний шилтгээнд нээгдэнэ. 15-16 орноос 30-40 хүн оролцох төлөвтэй байгаа, эдгээр орон болон ирнэ гэж үзэж байгаа төлөөлөгчдийн нэрсийг Зборовский ирүүлсэн аж. Их хурал “Нийгмийн хувьсгалын дэлхийн нам”-ыг батлах зорилттой. Шарок нэгдсэн мэдээгээ ажлын өдрийн сүүлээр Судоплатовт илтгэв. Дарга нь их хурлын бүх техник ажилтны нэрсийг Зборовскийгээс нэхэж авахыг тушаалаа.

– Павел Анатольевич, би өнөө орой хувийн зарим нэг ажилтай. Долоон цагийн үед явахыг зөвшөөрнө үү гэж Шарок өгүүлэв.

– Тэг тэг, дуртай цагтаа яв, өнөө орой таны хэрэг гарахгүй.

Шарок өрөөндөө буцаж ирээд, ширээнийхээ шургуулгыг түгжиж, ширээнийхээ чийдэнг унтраатал дотуур утас хангинаад явчихсан чинь түүнийг нэн даруй ардын комиссар нөхөр Ежов дээр очихыг тушаах нь тэр.

Хоёр жилийн өмнөх шиг Шарок дахиад л ардын комиссариатын байрны зүүн жигүүрийн зүг урт урт гудаагаар нэг өгсөн, нэг уруудан, шатны тавцан болгон дээр харуулд үнэмлэхээ шалгуулан алхахдаа Ежов түүнийг яах гэж дуудсаныг дахин дахин эрэгцүүлж явав. Абакумов ямар нэг юм хэлчихэв үү? Юу л бол. Париж уу? Бүх юмыг Судоплатовт илтгэчихсэн. түүнээс гадна одоо гадаад хэлтэс Бериягийн харьяанд байгаа. Тэгэхээр Ежов түүнийг алгасаж байгаа болох нь уу? Тэгвэл Берия хожим мань Шарок дээр тоглож хариугаа авна. Бүхэлдээ энэ дуудлагаас олигтой юм горьдох үндэс алга.

Шарок нарийн бичгийн даргын хамт танил өрөөн дундуур өнгөрөв. Бүх юм хуучнаараа, нөгөө л мундаг том ширээ, хана дагасан шилэн шүүгээнүүд, нөгөө л үнэтэй тавилга, цонхны битүү хөшиг, суудлын ард өлгөсөн Сталины хөрөг. Нарийн бичгийн дарга арын хананы хаалгыг тогшсонд “Ор!” гэх сөөнгө дуу хадлаа. Нарийн бичгийн дарга хаалга онгойлгож, Шарокийг оруулаад буцав.

Ежов жижгэвтэр өрөөнд буйдан дээр сууж байна. Цамцныхаа ханцуйг шамалчихаж, үс нь өрвийчихэж, ширээн дээр баахан лонх, тавагтай зууш байна. Шарокийг булингартсан харцаар сонжин хартал утас нь дуугарлаа. Ежов харилцуурыг авч чагаснаа, бүдүүлгээр хариулж байна:

– Би орос хэлээр бүгдийг нь тайлбарласан. Ойлгоогүй ээ? Тэгвэл ... руу тонил...

Муухай билэндэж хараагаад утсаа хаялаа. Согтуу төдийгүй уймарч түгшсэн байх аж. Шарокийг дахиад булингартсан нүдээр сэжигтэй харснаа,

– Илтгэлээ тавьсан уу? гэж асуув.

– Ёсоор илтгэсэн, нөхөр ардын комиссар хэмээн Шарок номхон зогсож илтгэв.

Ежов түүнийг суу гэсэнгүй.

– Эх орноосоо хол амьдарч залхаагүй байна уу?

– Алба юм чинь, нөхөр ардын комиссар.

– Алба... Албыг сольж болно.

– Юу гэж тушаах сан бол, нөхөр ардын комиссар.

– Тэгвэл Усан тээврийн ардын комиссариатын албанд шилжихийг тушаана даа. Чи үүнийг юу гэж үзэж байна?

– Тушаал бол тушаал, нөхөр ардын комиссар.

– Чи юу гээд бураад байна аа: тушаал, тушаал... Усан тээврийн ардын комиссариат руу, над руу шилжих хүсэл байна уу? гэж асууж байна.

Шарокийн толгойд элдэв бодол хуйлран эргэлдэв. Аюулаас хамгаалахад ажиллах осолтой болсон, иргэний албанд шилжвэл зүгээр сэн, гэхдээ Ежвтой хувь заяагаа холбоно гэдэг бол бүр осолтой.

– Яагаад дуугарахгүй байна?

– Ямар ажил гэдгийг мэдэхгүй байна, нөхөр ардын комиссар.

– Ажил хүрэлцээтэй байна, харин ажилтан алга байна, дандаа хорлон сүйтгэгчид, чалчигчид, ойлгов уу?

– Ойлгомжтой. Гэхдээ би хуульчийн мэрэгжилтэй, тийм ч учраас намайг ийш нь авсан. Харин усан тээвэр... Энэ чинь юу гээчийг хүртэл би мэдэхгүй байна.

Ежов хундагатайгаасаа дахин нэг балгаснаа, ширээг нэгжих мэт тойруулан харсан боловч зуушнаас юу ч амссангүй. Тэгээд Шарок руу харалгүй,

– Мэрэгжлээр чинь ажилд тавина. Хуулийн хэлтэс ч байгаа, бас боловсон хүчнийх ч бий, тусгай хэлтэс ч бий гэв.

– Жаахан бодохыг зөвшөөрнө үү, нөхөр ардын комиссар.

Ежов түүн рүү булингарт нүдээрээ ёозгүй харахад, Шарок айсандаа зүрх нь ширхийгээд явчихав.

– Хүсэхгүй байна! гэж Ежов хорон муухай өгүүлэв.

– Жаахан бодох гэсэн юм, нөхөр...

– Бүх юм тодорхой байна! хэмээн Ежов үгийг нь тасдаад, – Яв! гэлээ.

Большая Лубянкад байдаг ДЯАК-ын дэлгүүрээс Шарок архи, дарс, зууш худалдан авч цүнхээ дүүртэл чихэв. Тэдний байр Остоженкад, Зачатьевийн хөндлөн гудманд байдаг билээ. Хориод оны үед нэг нэпман баячуудын байшингаас тэр байрыг тасдаж авчээ. Тэр нэпман аль хэзээний Нарымд юм уу, Соловкад мажийсан, оронд нь нэг профессор орсон, тэр нь ч бас Колымд юм уу, Воркутад погдойсон, тэгээд Шарок уг байрыг авсан ажээ.

Хоёр өрөөтэй, гал тогоо, халуун усны өрөө, жорлонтой, ханын хос шүүгээтэй, адрын агуулахтай, товчдоо, байх ёстой бүх юмтай, нэмэрт нь Шарокт эвтэйхэн, эцэг эх нь суудаг Арбат холгүй, байгууллагад нь ч аятайхан, ажилтан нь хилийн чанадад байгаа үед байрыг нь мэдээлэгч нартай нууц уулзах байр маягаар ашиглана; түлхүүрийг нь хэлтэс хадгална. Хоёр дахь түлхүүр эцэг эхэд нь байгаа, тэд бүтэн сайнд ирцгээнэ, энэ өдөр уулзалт байлгахгүй гэж тохирсон байгаа. Каля: “Хүсвэл байрыг чинь харж хандаж байя” гэж ам нээсэн боловч мань хүн хариуд нь: “Хонгор минь, миний байгууллагад харж хандах хүн байхгүй гэж үү? Чи надгүйгээр ийшээ ойртож хэрхэвч болохгүй” хэмээн хямсалзсан. Халуун усны өрөөнд Калягийн халаад байнга өлгөөтэй байдаг нь түүний зөвшөөрүүлж чадсан ганц юм ажээ.

Гэхдээ Шарокийг Москвад ирэх тоолонд Каля эзэгтэйн үүргийг хичээнгүйлэн гүйцэтгэж, угааж арчиж, эмхэлж цэгцлэн, ийн уулзах болсоор аль хэзээний гурван жил болчихлоо, эрхбиш нэг тийш нь шийдэх цаг ирсэн гэх маягтай, гэр орны ажилд яггүй дөртэйгөө харуулна. Тэгээд бүлэрхүү том гартай, бие хаа дажгүй, сэтгэл хөөрсөн тэрээр өнөөдөр ч гэсэн идээний ширээ төхөөрөөд сүйд байна. Дагуулж ирсэн найз нь чихэндээ шармал ээмэгтэй, урт цэх хөлтэй, хар үстэй, цыган маягийн өндөр хүүхэн аж. түүнийгээ,

– Миний найз Аза хэмээн танилцуулав.

Янжуур баагуулан буй найз нь,

– Цыган хүүхэн Аза гэж нэмж өгүүлэв.

Абакумовт ч өөрийгөө бас тэгж танилцуулав:

– Цыган хүүхэн Аза.

– Нээрэн гэж үү? хэмээн Абакумов эргэлзэн асуув.

– Адилгүй байна гэж үү?

Аза цыган шиг мөрөөрөө биелэж үзүүлэв.

– Энийг чинь бид ч чадна...

Абакумов, мэдээж, яаж Азад хүрэх вэ, гэхдээ л тарган мөрөө бас цыган биелгээ шиг чичрүүлсэнд Шарок хэрдээ гайхав.

– Манай сүргийнх байна хэмээн Аза догиов.

– Бас бид нэгэн асарт унтана даа гэж Абакумов нэгтгэн дүгнэв.

мань хүн энэ хоёрыг аль хэзээний мэддэг мэт аяглан буй нь таних танихгүйгээ ялгахаа больтлоо эмс охидыг эмээллэж явсны шинж. Бөөн сүр, сүр сархийн орж ирсэн, боодолтой юмтай араас нь орж ирсэн жолооч хэзээ, хаашаа ирэх шийдвэр аваад гарч одсон. Шарокт,

– Энэ боодлыг задал гэж тушаал буулгасан.

– Виктор Семёнович, яах гэж энэ вэ? Хар л даа, ширээн дээр бүх юм байна.

– Нэмэгдэл хүч хор болохгүй. Наполеон юу гэж ярьж байсан билээ? Ялахын тулд юу хэрэгтэй вэ? Гол чиглэлд гол хүчээ төвлөрүүлэх хэрэгтэй. Ямар вэ, хүүхнүүд ээ, Наполеон Бонапарт зүйтэй ярьж байж уу? Тийм хүнийг мэдэх үү? Тярле-г уншицгаасан уу?

Хүний нэр ч зөв дуудчихаж чадахгүй адгийн новш гэж Шарок бодов. Тярле-г өөрөө уншаагүй дээ, Сталин түүний академич цолыг сэргээхээр зарлигдсаныг олж мэдсэн хэрэг, тэгээд тэр даруй түүний “Наполеон” гэдэг номыг худалдаж аваад номынхоо тавиур дээр тавьчихаа биз.

Хөлөө ачаад, тамхи баагиулж суугаа Аза,

– Наполеоныг мэднэ ээ, уншилгүй яахав гэв.

– Шалгана аа гайгүй, харин одоо бол юм амхарцгаая, багачууд аа, би чоно шиг өлсөж явна гэж Абакумов алиалав.

Каля энэ хооронд боодлыг задалж, армян коньяк, түрс, хулд загас, утсан гахайн мах, усан үзэм сэлтийг ширээн дээр өрж тавив.

– Юунаас эхлэх вэ? гээд Абакумов цагаан архи руу гараа явуулав.

– Гарт юу байна, түүнээсээ л эхлэе гээд Аза ээмгээ шаргиулав.

– Зүйтэй шүү, ууя гэвэл архийг, хайрлая гэвэл гоёыг, хулгайлъя гэвэл саяыг гээд Абакумов Аза руу хараа шидэв.

мань хүн: танилцсаны төлөө, хүүхнүүдийн төлөө, Калягийн төлөө, Азагийн төлөө, Юрагийн төлөө, төрөл төрөгсдийнхөө төлөө, ойр дотныхныхоо төлөө гэхчилэн хундага тавилгүй ууж, бусдыг албадан уулгаж байв... Бас идэх юмнаас ёстой гахай шиг гударч, тэр ч бүү хэл бүр хуугчиж байлаа.

Юра болгоомжтой ув. Юм ярих учиртай. Амьдралаараа дэнчин тавьчихсан байгаа. “Шпигельгласын хэрэг” гээд зохионо, тэгэхээр хамсагчид хэрэгтэй болно. Харин Ежов бол түүнийг өөр ардын комиссариат руу шилжүүлэн аварч байгаа хэрэг. Мэдэж бай, би чамайг аварч байна шүү! Өө, дургүй байна уу, тэгвэл зовлонгоо өөрөө эдэл! Бүр өнөө шөнө гэхэд түүнийг барихаар ирнэ. Тэгээд хүүхэнтэй хэвтэж байгаа Абакумовыг бас олно. Нөхөр

журмын ёсоор урьдчилан анхааруулвал зүгээр сэн. Гэтэл энэ нөхөр үнэлэнэ гэж үү? Хэлсэн даруй арилаад өгнө. Тэгээд шоронгоос ч гаргая гэхгүй. Яадгийм, энэнтэй л нэг уяанд орохоос. Өнөө шөнө ирэхгүй бол маргааш Абакумов арга хэмжээ авна. Аминд орох ёстой. Эс тэгвээс, Шарокийг шоронд хийх юм бол мань эр бас шатна. “Хэнтэй уулзаж байсан бэ?” — “Нөхөр Абакумовтой. Манай гэрт хүүхнүүдтэй цуг архидаж байсан”. Тэгсэн цагт мултрах гээд үзэг л дээ!

Энгийн хувцастай ирсэн Абакумов энэ завсар пиджакаа тайлчихаад, үстэй цээжээ гарган цамцныхаа энгэрийг ярчихсан, үсэрхэг савраараа Азагийн банзал доогуур хэдийн тэмтчээд эхэлчихэж. Цаадах нь бас чамгүй балгачихсан, хүсэл тачаалын дүр эсгэн арваганаж байна. Каля ч бас нүд нь гялалзаад, инээд алдан, бөөн дуу шуу. Харин өөрөө бол толгой нь саруулхан байх ёстой. Абакумов зэрэг зиндаатай хэдий ч, яс үйрүүлэхэд нэг их ухаан хэрэггүй, Парист ийм юмыг явуулалтай нь биш, тэнд бол зөвлөлтийн тагнуулын албыг үүрч яваа Шпигельгласчууд, Судоплатовчууд, Шарокчууд — мэрэгжлийн хүмүүс хэрэгтэй. Өөрөө генерал Скоблин, сайд Третьяков энэ тэрийн учрыг олж байсан, ичих нүүргүй Абакумовын ч учрыг олно, ажил явдалдаа албадан оруулна, хүчээр оруулна. Гагцхүү согтохгүй л юм сан. Шарок архины оронд өөртөө сэмхэн нарзан хийнэ, ашгүй зузаан ногоон шилэн хундагатай болохоор рашааны хий нь харагдахгүй байгаа, тэгээд ч түүний яаж ууж байгааг Абакумов хянаж байгаа юм алга. Цаадах нь өөрөө л ууж идээд, Азагийн банзал доогуур тэмтчээд, хажуугаар нь Каля руу бас хараа шидлэн: “Энэ ч ёстой хөхүүр юмаа, мундаг хүүхэн, байхгүй юм алга” хэмээн хөх рүү нь хуруугаараа хатгална. Шарокийг байхгүй бол хоёуланг нь дараад авах байсан байх.

Дараа нь эгшигт хайрцаг тавихыг шаардаж, Азатай бүжиглэхээр босов. Согтуу хэрнээ бүдүүн, булиа эрийн хөл нь чанга байгаа гэж учиргүй, ямар танц гишгэж байгаа нь ойлгомжгүй ч бүр элдэв мурчиганасан хөдөлгөөн хийж, тэр дундаа Азаг тайчин, хамаг товчийг нь мулталж, богино өмдөн дотуур нь гараа явуулж элдэвлэхэд хүүхэн ажрах царай алга, гагцхүү, сайн санаат хүн ард минь хараач, ямар гээчийн дүрсгүй тархи вэ гэх янзтай толгой сэгсрэн, Каля, Шарок хоёр руу донжтой харна.

Пянз тоглож дууслаа.

– Хаана амсхийж болохов? гэж Абакумов хүрхрэв.

Шарок унтлагын өрөөний хаалга руу заав.

Абакумов Азаг гараас нь угзран,

– Асартаа орцгооё, цыган минь гэв.

Аза дахиад нөгөө хоёр руугаа донжтой харж, энэний намайг яаж байгааг хараач гэх шиг дал мөрөө хавчсан хэрнээ Абакумовын араас үг дуугүй дагав.

Шарок, Каля хоёр буйдан дээр хэвтлээ.

– Өглөө Азаг аваад халуун усны өрөө рүү орж, тэндээ нэг хэсэг байгаарай, би Виктор

Семёновичтой ярилцана гэж Шарок хүүхэндээ хэлэв.

Гэвч өглөө болохыг хүлээх боломж гарсангүй. Дөнгөж зүүрмэглэх шиг болтол Абакумовын дуу түүнийг сэрээчихэв. Шарок гараа явуулан буйдангийн дээрх ханын чийдэнгээ асаалаа. Абакумов ганц шуудагтай, өрөөний голд гэдсээ унжуулан зогсож байв. Урт дотоожтой Аза ширээний ард сууж харагдана.

– Эр хүн гуай, унтаж болоо биш үү, гадаа хавар болж байна шүү дээ... гээд Абакумов Азагийн дэргэд тухлан сууж, нарзан аягаласнаа, – Ахан дүүс минь босцгоо, дахиад жаахан наргицгаая гэв.

Шарок цагаан даавуун доогуураа шуудгаа өмсөж босоод, бас ширээ рүү очиж суулаа.

– Бос, Каля! гэж Абакумов тушаав.

– Та цаашаа харж бай, Виктор Семёнович, би нүцгэн байгаа.

– Өөр яалгах сан бол! Би л шалдан хүүхэн үзээгүй байж гэнэ.

Каля гараараа халхлан халуун усны өрөө рүү гүйж ороод, халаадтай буцаж ирэв.

Шарок Аза руу дохиж,

– Явж усанд орцгоо. Би дуудна гэв.

Хоёр хүүхэн явж, халуун усны өрөөнөөс төдөлгүй ус шуугих чимээ гарлаа.

Абакумов хоёр биендээ архи хундагалав.

– За татчихъя.

Ууцгаалаа.

– Виктор Семёнович, би тантай зөвлөмөөр байна.

Шарок Ежовтой ярьсан зүйлээ түргэн бичлэгийн тэмдэглэл унших мэт нэгд нэгэнгүй яриад, Ежов сэтгэл дундуур үлдсэнийг бас хэлэв.

Абакумов зуушнаас ээлжлэн сэрээдэж, зажлах зуур Шарокийг харсхийж байв.

– Судоплатовт илтгэсэн үү?

– Хэдийдээ амжих вэ? Николай Иванович намайг оройтуулж гаргасан. Танаас хождох вий гэж бас айсан юм. Та Судоплатовыг надад туслаж чадна гэж бодож байна уу?

– Чадахгүй, гэхдээ мэдэж байх ёстой гэж Абакумов гэнэт эрүүл юм шиг нухацтай хариулав. – Нөхөр Берия Лаврентий Павлович түүнийг дуудаад: “Таны ажилтнуудыг өөр ардын

комиссариат руу урвуулж байгааг та мэдэж байна уу?” гэж асууна. — “Үгүй ээ, мэдэхгүй байна” гэж Судоплатов хариулна. “Өө тийм бий, тэгвэл, нөхөр Шарок бидний ар хударгаар хэлэлцээ хийж байх нь. Давхар тоглоом тоглож байна! Үүнийг юу гэж үзэх вэ?!” Миний санааг ойлгов уу?

– Таны зөв, Виктор Семёнович.

– Өнөөдөр, ажилдаа очингуугаа шууд Судоплатов дээр ор. Надад ярьсан шигээ бүх юмаа ярьж өг. “Зөвшөөрсөн үг хэлээгүй. Танд илтгэх үүрэгтэй гэж үзэж байна” гэж онцол. Тэгчихээд амар жимэр сууж бай. Юу гэхийг нь хүлээ. Бусдыг нь би янзалчихна.

мань хүн гэнэт урагш бөхийж, Шарокийг духайн харлаа.

– Абакумов үнэнч анд нараа мартдаггүй хүн. Ойлгов уу?

– Ойлголоо, баярлалаа, Виктор Семёнович.

– Алив, үүний төлөө ууцгаая. Чи оройжингоо архины оронд нарзан залгилсан. Би харсан л даа. Ойлгож байна: чи энэ ярианд бэлтгэж байсан. Буруушаахгүй байна. Харин одоо бол ууцгаая.

Тэгээд гэдсхийн жүнзээ хоослов.

– Чиний ажлыг дуусгачихлаа, одоо наргицгаана. Дуунд юу билээ: “Ууцгаана, наргицгаана, амьдрал товчхон, ханатал цэнгэнэ” гэдэг бил үү? Аза дажгүй, сурмаг хүүхэн байна, Каля ямар байна?

Шарокийн согтуу хийсэх мэт алга болох нь тэр, энэ асуултын далд санааг ойлголгүй яахав.

– Каля бид хоёр анх яаж юм байгаа биш, Виктор Семёнович, бүр яахаар бодож...

Абакумов үгийг нь гүйцээлгэлгүй дундуур нь оров:

– За тэр дээ, чи шинэ шөлний амт үзэх хэрэгтэй. Хоёулаа сольё!

Яах ч арга алга, мань хүн энэ гахайны саварт орчихож. Өнөөдөр Ежов дээр ороод, “Өчигдөр ажлынхаа хуучин нөхрийн хувьд Шарокийнхоор орлоо, тэгсэн чинь тэр муу нохойн гөлөг, таныг элдвээр муулаад, согтуу сууж байна. Та аюулаас хамгаалахаас түүнийг урвуулах гээд байна гэнэ, ёстой хүний шаар, заяагүй балай!” гээд илтгэчихнэ. Тэгсэн байхад өөрийг нь шууд хэлтсээс нь аваачаад буудчихна, яриад байх юм товчхон!

– Таны дараа би Азад юу болох вэ дээ? хэмээн Шарок инээвхийлэв.

– Залуу хүн, дөнгөлгүй яахав! Нөгөө охидууд хаачив?

мань эр босч очоод, халуун усны өрөөний хаалгыг бага зэрэг онгойлгов...

– Булхацгаачихав уу?! “Бүсгүйчүүд булхацгааж л байна, дэлэн хөх нь булхалзаж л байна” гэж дуулдаг шиг.

– Одоо хувцаслаатахья, Виктор Семёнович гэж Каля өгүүлэв.

– Хувцаслах хэрэг юу байна? Тэртэй тэргүй тайчих юм чинь.

– Болъё чиминь, бидэнд хувцастай нь дээр.

Каля халаадтай, Аза дотоожтой гарч ирэв.

Абакумов тэр даруй бүгдэд нь архи хундагалалаа.

– Алив, хүүхнүүд ээ, олмоо чангалаарай.

Шарок гал тогоо руу орж, Каляг дуудаад баргар царайлан, санааширч,

– Би энүүнтэй ярилаа, туслая гэж ам гарлаа. Энүүнээс миний хувь заяа төдийгүй амьдрал маань хамаарна. Ойлгов уу? гэв.

– Мэдээж, ойлголгүй яахав хэмээн Каля халирсхийн өчив.

– Аза түүнд таалагдсангүй, маяглаад байна гэнэ. Маяглаад байх юм битгий авчраарай гэж би чамд хэлсэн шүү дээ. Чи орноос нь нөхөж ажиллах хэрэгтэй болж байна.

Каля түүний юу хэлснийг эхлээд ойлгоогүй боловч санааг нь тэгсхийгээд ухаармагц эгдүүцэн дүрэлзээд явчих нь тэр.

– Чи чинь юу вэ, солиороо юу? Тэгвэл би яг одоо шууд явлаа! Чи чинь юу ярьж байна аа?!

– Сонссоныг чинь л ярьж байна. Миний төлөө, миний амьдралын төлөө гээд хүүхний бугуйнаас байдгаараа чанга базаж авав. – Би чамаас гуйя. Чи бид хоёр энэ тухай хэзээ ч эргэн дурсахгүй, андгайлж байна. Гүйцээ! Мугуйдалж зөрөх гэж бас оролдов оо! Урьдаас анхааруулья! Чи очихгүй бол би алуулна, гэхдээ чи ч бас алуулна шүү!

Тэр хоёр ширээ рүү буцаж ирэв. Абакумов аман дах гахайн махаа гүйцээж заглах зуур,

– За одоо бүжигэцгээе. Юрка, хөгжмөө тавиарай. Алив, Каля, хоёулаа жаахан дэвхцээтэхье гэж хашгарав.

Үсэрхэг, бүдүүн, шалдан эр хүүхнийг тэврэн авч бие рүүгээ шахан, өрөөн дундуур займчихдаа гарыг нь шуудаг руугаа шургуулах гэж оролдсоор, унтлагын өрөөний хавьд очиж таармагц, хаалгыг нь онгойлгон Каляг тийш нь түлхчихэв.

Хүүхэн эргэж Шарок руу царайчлан харав.

мань эр өөдөөс нь гараа эрсхэн дохиж тушаав: орооч!

Өглөө нь Шарок Судоплатов дээр орж, Ежовтой ярилцсан зүйлээ илтгэв.

– Ийм асуудлыг шийдэх чинь таны хувийн хэрэг гэж Судоплатов хэнэггүй өгүүлжээ.

Гэтэл орой нь Шарокийг Лаврентий Павлович Берия руу дууджээ. Шарок Бериягийн зөвхөн хөргийг л харсан билээ. Зураачид зулгуйдаж байсан нь мэдээж, гэхдээ амьдрал дээр бол Бериягийн царай агаар хийлчихээд хавчдаг шил өлгөчихсөн юм шиг ер бус гөлчгөр аж.

Өрөөнд нь Бериягаас гадна хоёр хүн байсны нэг нь Судоплатов, нөгөө нь Серебрянскийтэй төстэй нэг түшмэл. Тэр түшмэл цэвэрхэн царайтай, гялалзсан нүдтэй учраас нүдэнд дулаахан, гоё хүн шиг санагдав.

Шарок ирснээ номхон зогсож байгаад илтгэв.

– Та суу!

Берия гологносон нүдээрээ Шарокийг өрөмдөн,

– Зборовскийн нөхцөл байдал ямар байна? гэж асуув.

– Лев Седовыг үхсэний дараа түүний хадгалж үлдсэн ганцхан юм нь троцкист олон улсын нарийн бичгийн дарга нарын газраар орох эрх гэж Шарок товхийтэл хариулав.

– түүнийг Троцкийн хүрээлэл рүү нэвтрүүлэх боломж бий юү?

– Маш бага. Зборовскийг Седовыг алсан хэрэгт сэжиглэцгээсэн. Сэжиг арилсан. Седовын дэргэдээс түүний авгай Жанна Мартен ерөөсөө салдаггүй байсан, Седовын хоолонд Зборовский гар хүрээгүй. Тэглээ ч гэсэн үл итгэх байдал үлдсэн. Зборовский Мексикт очих зөвшөөрөл Троцкийгоос хүссэн боловч цаадах нь өгөөгүй.

Судоплатовын дэргэд суугаа түшмэл Шарокийг сонжин харж байв.

– Цаашид ямар төлөв байна гэж та харж байна? гэж Берия асуув.

Троцкийг устгах тухай асуудал гэдгийг Шарок сайтар ойлгож байгаа боловч өөрөө бол зөвхөн санал болгосон хүрээнд, өөрөөр хэлбэл, Троцкийн хүрээлэл рүү хүн оруулах тухай л ярих ёстой. Шарок өөр нэг юмыг бас ойлгов: мань эр Бериягийн хүн болж мэдэх бас нэг горьдлоготой болж байна. тэрээр үгээ сайтар цэгнэн байж ийн өгүүлэв.

– Троцкий рүү нэвтрэх гэсэн төлөвлөгөө анхнаасаа бодитой бус байсан юм шиг надад санагдах юм. Түүн рүү цагаантны хүн шургуулах санаа байсан, хүмүүсийг Туркул, Миллер, Драгомиллов нарын генералууд бэлтгэсэн. Туркт, бас Европт ч гэсэн тэдэнд ямар нэг горьдлого байсан бол Мексикт өчүүхэн ч байхгүй. Троцкийн хамгаалалтынхан америкчууд, мексикчүүдээс бүрдэж байгаа, тэдний дотроос л хүн сонгож авах хэрэгтэй. Мексик хүн бол илүү, ямар ч байсан испани хэлтэй хүн дээр.

– За тийм байж... гэж Берияг хэлэхэд, өөрөө байг нь олж дээ, өөрийнх нь санаа эдний

төлөвлөгөөтэй таарч байгаа юм байна гэсэн нэгэн аяс түүний дууны өнгөнөөс Шарокт ойлгогджээ.

– Есдүгээр сарын гурванд IV Интернационалын зохион байгуулах их хурал болох нь. Та маргааш гэхэд Парис руу явж, энэ эх адаггүй ярианы байдлыг мэдэж байвал зохино.

– Мэдлээ гүйцэтгэе, нөхөр Берия!

мань хүн түүнийг овгоор нэрлэлээ. Өнөө маргаашгүй ардын комиссар болох гэж байгаа хүнийг “ардын комиссарын орлогч” гэж нэрлэх нь тэнэг явдал болох байсан.

– Таны дарга нар... гээд Берия Судоплатовын зүг дохиж, – Павел Анатольевичийг та танина... гэв.

– Тийм ээ, танина.

Берия Судоплатовын дэргэдэх хүн рүү эргэж,

– Наум Исаакович Эйтингон хэмээн танилцуулав.

Эйтингон Шарокт гараа өгөн инээмсэглэв.

– За ажиллаад байцгаая.

Одонгоор шагнуулсны дараа Вадимын байр суурь ихэд бэхжиж, түүнд “Баруун троцкистуудын зөвлөлтийн эсрэг эвслийн” хэргийг шүүн таслах ажиллагаанд Холбоотын ордны Октябрийн танхимд нэг өдөр орох үнэмлэх олгохдоо хүрсэн байна. Тийм нэр төр олон нийтийн санаа бодлыг шаардлагын хэмжээнд бүрдүүлж чадах зөвхөн алдар цуутай зохиолч нарт оногдож байсан юм.

Вадим итгэлийг биелүүлж чадна гэдэгтээ эргэлзэхгүй байжээ. мань хүн үзэг нэгт ахан дүүс шигээ эдүгээ “Алуурчин, тагнуулчдын бузар бүлгийг маш хатуу цээрлүүл”, “Устга!”, “Гүйцээж сөнөө!” гэхчилэн нэг хэвээр цутгасан мэт эл дол болсон, хэдэн зуугаараа хэвлэгддэг сонины ердийн мэдээ өгүүлэл бичихгүй. тэрээр улс төрийн гэмт хэргийн сэтгэлзүйг судлаж, 1934 онд зохиолчдын нэгдүгээр их хуралд Бухарины тавьсан илтгэлээс өнөөгийн шүүн таслах ажиллагаа хүртэлх учгийн холбоог тогтооно. Яруу найргийн тухай... яруу найргийн тухай илтгэл алуурчин тагнуул тавьж байж. Сэхээтэн, гэмт хэрэгтэн хоёрыг заагладаг ирмэг хаана байна вэ? Плетнев, Левин, Казаков — анагааж аварч байх ёстой эмч нар Үхлийн хамсаатан, гар хөл болсон. Хүмүүнлэг үзэлтэн, гэмт хэрэгтэн хоёрыг заагладаг ирмэг хаана байна вэ? Эдгээр асуултад мань хүн тов тодорхой, яв цав, нэр төртэй хариулт өгнө: жинхэнэ сэхээтэнлэг ёс, жинхэнэ хүмүүнлэг ёс гагцхүү Ленин–Сталины намд үнэнч зүтгэснээр л бололцоотой болно. За ийм үзэл санаагаар эхэлчих хэрэгтэй, тэгсэн цагт гар өөрөө бичээд явчихна.

Танхимд байгаа бүх хүний нэгэн адил Вадим тайзан дээр юу болж байгааг амьсгал даран ажиглаж байв. Ээ тэнгэр минь! Бухарин, Рыков хоёр — нам, төрийн удирдагч байсан хүмүүс. Ягода — ДЯАК-ын бүхнийг чадагч тэргүүн, зөвхөн нэр нь л аянга мэт айдас төрүүлдэг асан, сая сая хүний хувь заяаг шийдэж байсан ардын комиссарууд, намын ТХ-ны нарийн бичгийн дарга нар, одоо бол няц цохиулсан, арчаагүй амьтад, ялтны сандалд суучихсан, бос гэнгүүт босч, суу гэнгүүт сууж, адгийн муухай гэмт хэрэг үйлдсэн хэмээн дуртайяа улайцгааж байна. Ямар үнэ цэнээр эднээр хэрэг хүлээлгэснийг Вадим мэдэхгүй, мэдэхийг ч хүсээгүй. тэрээр, шүдээ цөм цохиулсан, нүүр нь бөөн цус нөж болсон Сергей Алексеевичийг нэхэн санахад л энэ тухайд зөвхөн таамаг л тавьж чадна. Харин мань хүн эдгээр хүмүүсийг өчүүхэн төдий ч өрөвдөхгүй байв. Бүгдээрээ “Вацлавууд” байх заавал албатай тогтолцоог эд нар бий болгоогүй гэж үү?! Ер нь ч энэ сэтгэлийн сэв гэгч тэнэг ойлголтыг боливол таарна!

Вадим арын эгнээгээр сууж байгаа боловч Октябрийн танхим авсаархан болохоор бүх юм илхэн байна. Бухарин, Рыков хоёрыг хэн хүнгүй хөргөөр нь таньдаг учир мань Вадим ч тэднийг шууд таньжээ. Бас эцгийнх нь багш, тэднийхээр байн байн орж гардаг байсан профессор Дмитрий Дмитриевич Плетневийг танилаа. Эцэг нь түүнийг гарамгай авьяастан, бүр суу билэгтэн, дэлхийн хамгийн аугаа их эмч нарын нэг гэж хэлдэг байсан. Өнгөрсөн оны зургадугаар сарын “Правда”-д “Профессор – хүчирхийлэгч, тамлан зовоогч” гэсэн өгүүлэл гарсан. Профессор Плетнев нэг өвчтөнийг үзэж байхдаа хөхнөөс нь хазчихсан юм шиг, тэр гэмтлээсээ болон сэтгэлийн хүнд цочрол амссаны улмаас сайхь эмэгтэй тахир татуу болсон юм шиг зүйл бичсэн байсан. Тэр эмэгтэйн захидлыг хавсаргаж, сонин түүнийг нь “гайхаш тасалсан хүмүүний баримт” гэж нэрлэсэн байсан. Маргаашаас нь сонины бөмбөгдөлт эхэлсэн. Олон профессоор, нэртэй эмч нар, эмнэлгийн хамт олон жаран тавтай

“хүчирхийлэгч, тамлан зовоогчийг” зүхлийн муугаар зүхэцгээсэн. Харин Вадим эцгийнхээ нэрийг тэр зүхэгсдийн нэрс дотроос олж хараагүй, Андрей Андреевич Бүх Оросын болон Москвагийн дотрын эмч нарын онц хуралдаан дээр ч бас үг хэлээгүй аж. Вадимын байдал эгзэгтэй байгаа: эцэг нь үгээ хэлэх дургүй байгаа, ингэж дуугарахгүй байгаа нь Вадимд ч хүндээр тусч мэднэ. Гэтэл эцгийнхээ уурыг хүргэчихнэ, сөргөөд өөрийг нь буруушаана, түүгээр ч барахгүй илчилж мэднэ – “Вацлав”-ын тухай эцэг нь гадарлаж байгаа, аягүй бол, мэдэж байгаа ч юм шиг өөрт нь санагдаад байгаа болохоор энэ бүхнээс айгаад эцгийнх нь дуугүй байгаа мань хүнд ч муугаар нөлөөлж болохыг хэлж зүрхлэхгүй яваа. Салан задгайгаас болоод ямар нэг мэдээллээ өрөөнийхөө ширээн дээр ил орхичихсон, түүнийг эцэг нь олоод уншчихлаа гэж үү дээ? Тэгсэн бол мөн аймаар аа. Тийм ч учраас одон авахад нь баяр хүргээгүй, ерөөсөө ажил явдлыг нь ч сонирхохоо больсон байж магадгүй. Гэхдээ тэгэхэд, гучин долоон оны зургадугаар сард, Вадим эцгээсээ ямар ч муу юм бодолгүй,

– Дмитрий Дмитриевичийн энэ явдал чинь юу юм бэ? гэж асуусан.

– Чи чинь сонин уншдаг шүү дээ, мэдэж байгаа байлгүй.

– Мэдээж уншилгүй яахав. түүний мэрэгжил нэгтнүүдийн хэлж байгааг ч уншиж байгаа. Тэд нар нь түүнийг буруушааж байна.

– Бүгдээрээ биш! хэмээн эцэг нь үгийг нь тасдав. – Бүгдээрээ гэхэд хаа ч байсан юм! Егоров, Сокольников, Гуревич, Каннабих, Фромгольц, Мясников энэ тэр энэ жигшүүрт явдлыг дэмжихээс татгалзсан. Ингэхэд, чиний эцэг ч бас татгалзсан.

– Хүн болгон өөрийн санаа бодолтой байх эрхтэй хэмээн Вадим эвлэрэнгүй хэлсэн.

мань хүн өөр юу ч хэлж чадаагүй. Плетнев тэгэхэд хэрэг хүлээсэн эсэхийг хэн ч мэдээгүй, хоёр жилийн тэнсэн авсан, гэтэл одоо энэ Октябрийн танхимд шүүгдэж буй хэргээрээ төдөлгүй дахиж баригдсан. Нэг муу голын хийтэй хүүхнийг хүчирхийлэх гэсэн оролдлогоос хавьгүй хүнд гэмт хэргийг одоо хүлээж байгаа юм.

Плетневийн байцаалтыг Вадим гойд анхааран сонсов. Зөвлөлт засгийг юу гэж ч муулдаг байлаа гэсэн, хамгийн мундаг нэр төртөн, нэр хүндтэнг бут ниргэдэг нэг л гойд юм энэ засагт байна. Ялагдашгүй догшин хүч, тэр хүчийг сөрсөн хүн аль муугаа үзнэ.

Эцэг нь одоо юу гэх бол? Плетнев үйлдсэн гэмт хэргүүдээ өөрөө хүлээчихлээ! Тэдгээр нь ямар хэрэг гэж санана! Одоо түүнд буудан алах ял нүүрлэхчээд байна. Тэгтэл түүнийг өмгөөлж юм хэлэх гэж оролдсон хүн болгон бас буудан алах ялд унана. Одоо эцэгт бултах арга байхгүй! Юу гэж үзэж байгаагаа хэлэх ёстой болно. Плетнев бол түүний багш нь, анд нөхөр нь. Тэр яахав! Эцэг эхээсээ, ах эгчээсээ, хүү охиноосоо няцаж байгаа юм чинь хамт ажиллагчаасаа, багшаасаа, шавиасаа няцах бол ёстой Бурханы зарлиг чухам.

Танхимд тэмдэглэл хөтлөх ёсгүй. Гэхдээ санаа оноогоо шүүн таслах ажиллагааны тухай шинэхэн сэтгэгдлийнхээ дагуу бүр өнөөдөр тэмдэглэж авах хэрэгтэй. Вадим гэртээ ирээд чухамхүү үүнийгээ ёсоор болгов. Сүрхий бахдалтай ажиллаж.

Төдөлгүй эцэг нь ажлаасаа ирж, пиджакаа тайлж гэрийн хүрмээ өмсөхдөө хуучин зангаараа зангиагаа тайлсангүй, ядрангуй хэрнээ муухай харж байв. Плетневийн тухай яриа эцэгт нь эвгүй гэдгийг Вадим ойлгож байсан хэрнээ тэссэнгүй. Бас хойш тавих нь зохисгүйг ч хэлэх үү. Эцэг нь зөрөх сөгөө байхгүй, ер нь зөрүүлж хэлэх юм ч ор байхгүй. Тэгээд мань хүн Феняг халахыг эцгээрээ зөвшөөрүүлнэ, эцэг нь Нелли Владимировна гэгч тэр нэг авхайгаар дамжуулан Викатай холбоо бариад байгаа, тийм ямарваа харилцаа холбоо барихыг болиулна. Нэмэрт нь, Плетневийн тухай түрүүчийн ярианд эцэгтээ мадлуулсныхаа хариуг авч бахаа хангахаас татгалзахад хэцүү буй. Эцэг нь одоо түрүүчийн удаагийнх шигээ донгосоон, бузар явдал, шившиг, солиорол, өдөөн хатгалга энэ тэр гэж ярьж зүрхлэхгүй. Өөр үг хэллэг хайхаас өөр аргагүй болно.

Вадим тахианы хөл мэрэх зуур (Вадим оройн хоолонд тахианы хүйтэн мах идэх дуртай, Феня орой явахдаа дандаа хүйтэн хоол бэлдэж орхидог юм),

– Холбоотын ордонд шүүн таслах ажиллагаан дээр байлаа, нүд хальтармаар юм, чамд энэ тухай илтгэе гэв.

Эцэг нь хоолоо дуугай идэх аж.

– Бухарин, Рыков, Ягода гурав бол дүүрчихсэн улс төрчийн оронцогнууд, тэдний хувьд бүх юм ойлгомжтой. Гэтэл эмч нар – Левин, Казаков, тэгээд гол нь Плетнев Дмитрий Дмитриевич. Би өөрийнхөө чихэнд итгэхгүй байсан шүү, мань хүн бүх юмыг хүлээн зөвшөөрөөд байх юм.

Эцэг нь таваг руугаа тонгойсхийн хоолоо идсээр байв.

– Би зөвхөн түүнийг л хараад байлаа, төлөөний этгээд, жүжигчин байж магадгүй гэж бодоод. Үгүй, яах аргагүй Дмитрий Дмитриевич юмаа, би чинь түүнийг энд, манайд, энэ өрөөнд өчнөөн удаа харсан шүү дээ, тэр яг мөн, түүний яриа, байж байгаа төрх энэ тэр нь ч яг.

Эцэг нь түүн рүү харахгүй, хоолоо чимээгүй идсээр.

– Юу түүнийг албадсаныг огт ойлгохгүй байна?! Куйбышевийг алсан, Максим Горькийг...

Андрей Андреевич хутга, сэрээгээ тавган дээрээ тавьж, амны алчуураар уруулаа арчаад, сандлынхаа түшлэгийг налснаа, Вадимын хажуугаар харж,

– Дмитрий Дмитриевич Куйбышевийг эмчилж байгаагүй гэж тайван өгүүлэв.

– Гэхдээ...

– Дахин хэлье. Дмитрий Дмитриевич Куйбышевийг эмчилж байгаагүй. Куйбышев хүнд ажлын өдрийн дараа зүрх саажсанаас гэнэт нас барсан. Задлангаар үхлийнх нь шалтгааныг зүрхний баруун титэм судсанд нөж бөглөрсөн гэж тогтоосон. Гэхдээ юу ч болсон байлаа гэсэн, Дмитрий Дмитриевич Куйбышевийг эмчилж байгаагүй.

тэрээр сүүрс алдав...

– Горькийн тухайд гэвэл олон жил уушигны хүнд өвчнөөр өвдсөн хүн. Архаг идээт бронхит, уушигны судасны хатуурал, уушигны тэлэлт энэ тэр зүрх-уушигны дутагдалтай хавсарч байсан. Туж мэнгэрлэж ханиалгана, эмч нар тамхиа хаяхыг шаарддаг байсан хэдий ч зогсоо зайгүй тамхи татна. Тэр ч байтугай уушиг нь цус алдах явдал гардаг байсан. Капри арал дээр юм уу Крымд бие нь дээрдэнэ, гэтэл Москвад ирэх бүрийд уушиг нь үрэвсэнэ. Гучин зургаан оны зургадугаар сард яг л тэгсэн. түүнийг Кончаловский, Ланг, Левин гурав эмчилж байсан. Тэднийг байлцуулан Дмитрий Дмитриевич түүнд хэдэн удаа зөвөлгөө өгсөн. Эмчилгээ туйлын зөв байсан боловч Горькийг аврах боломж байгаагүй. түүний үхлийн тухай эмнэлгийн дүгнэлтэд эрүүл мэндийн ардын комиссар, бүх эмчлэгч эмч нар гарын үсэг зурсан, тэднээс гадна профессор Сперанский, задлан хийсэн профессор Давыдовский хоёр бас гарын үсэг зурсан. Эдгээр эмч нараас нэгийг нь ч үгүйдээн гэрчийн хувиар шүүх хуралд дуудаагүй. Нэгийг нь ч! Хэрэггүй байж л дээ! Хамаг юмыг Плетнев, зол муутай Левин хоёр руу чихчихсэн. “Өрөвдөх сэтгэлгүй хорлогчдын бүлэг”! гээд Андрей Андреевич гэнэт ширээ шаав. – Өрөвдөх сэтгэлгүй хорлогчид чинь тэд нар биш, харин тэднийг шүүгчид, чухам тэд нар бол “өрөвдөх сэтгэлгүй хорлогчид”!

– Эцэг минь ээ! хэмээн Вадим дуу алдав. – Сэхээч! Чи юу яриад байна аа?! Эмнэлгийн шинжээчийн дүгнэлтийг шүүх хуралд үзүүлсэн шүү.

– Шинжээчийн дүгнэлт ий?! гээд Андрей Андреевич сая Вадимыг эгцлэн харахад, харцанд нь үнэнхүү адлан үзэн ядах занал хурсаныг үзээд Вадим хамаг бие нь хачин оргиод явчихав. – Чи тэр хүний шаарнуудыг шинжээч гэж нэрлэж байгаа юм уу?! Шинжээчдийн удирдагч Бурмин бол мулгуу, хулчгар барлаг! Кисловодскийн нарзантай арван жил ноололдох зуураа дотрын өвчний талаар мэдэж байсан яльгүй юмаа аль хэзээний хуу мартсан. Комисстоо хэнийг оруулсан байна гээч? Шершевский, Российский... Тэд нар бол дотрын эмч биш, тэд дотоод шүүрэл судлагчид, тийм учраас Плетневийн хэргийн тухайд шинжээч байж чадахгүй! гээд Вадимыг дахин адлаж ширэвтатав. – Ямар шившиг вэ! Шершевский чинь Плетневийн найз, гэр орноор нь орж гардаг хүн, тэгсэн чинь ингээд уравчихаж. Урвагчид, урвагчид, эргэн тойрон, хаа сайгүй, алхам тутамд урвагчид.

Вадим агзайгаад явчихав. Эцгийнх нь үгэнд, түүний адалсан харцанд дахиад л нэг битүү дохио байв.

Андрей Андреевич биеэ барьж амьсгаагаа дарах шиг болоод, аль болохоор тайван ярихыг хичээн,

– Мэрэгжлийн үүднээс шинжээчийн ажилд оролцох эрхтэй цорын ганц хүн бол Виноградов. Тэнгэрээс хий юм шүүрээд байдаггүй, боломжийн дадлагатай, Плетневийн шавь дотрын эмч хүн. Тэгсэн чинь шавь нь багшаасаа уравчих юм. Айчихгүй юу! хэмээн өгүүлэв.

тэрээр дахиад амьсгаа нь давхцан, хуруугаа гозойлгосноо,

– Бурхан тэднийг өршөөхгүй дээ. Шудрага бус шүүгчдийг ч. Хуурамчаар гэрчлэгчдийг ч гэж тасалдуулан хэлэв.

Эцэг нь буудан алах ял авахаас хавьгүй давахаар юм ярьж байна. Хэрэв мань хүн ийм юмыг

ажилтныхаа дунд, анд нөхдийнхөө дунд ярьж байгаа бол түүнийг маргааш гэхэд л баривчилчихна. Тэгсэн байхад өөрөө, Вадим өөрөө хэн болж харагдах вэ?! Эцэг нь ял авсан ардын дайсан, дүү нь зөвлөлтийн эсрэг үзэлтэнтэй суусан, Парист байгаа. Ийм байхад ямар ч одон, ямар ч “Вацлав” тус болохгүй. Нэг муу “Вацлав” үхсэн хойно оо! Энэ шүүх хурлаар яллуулагсадын тэн хагас нь “Вацлавчууд”!

– Эцэг минь, сэтгэлээ барь! Чи хамаагүй дэвэрч болохгүйгээ өөрөө мэдэж байгаа шүү дээ, гэхдээ бодоод үз л дээ. Плетнев бол манай мундаг дотрын эмч, чи түүнийг бүр “манай анагаахын бахархал” гэж нэрлэж байсан. түүнийг устгаж байх хэрэг засгийн газарт юу байна? Тэгэх тусмаа, чиний ярьж байгаа шиг, тэр ямар ч буруугүй юм бол?

– Буруутай, буруутай! хэмээн Андрей Андреевич захныхаа товчийг тайлан толгой сэгсрэв. – Гэхдээ тэр түүнийг буруутгаж байгаа юманд буруутай биш, буруу нь дэндүү их мэдэж байгаад нь байгаа юм... Тийм шүү! Оржоникизег алахад...

Вадим өндийв.

– Сэхээрээч, чи чинь юу яриад байна аа, эцэг минь?!

– Суу! Би юу ярьж байгаагаа мэднэ. Оржоникизег алсан, эсвэл тэр өөрийгөө буудсан, сумны шархтай байсан юм чинь. Гэтэл эмнэлгийн дүгнэлтэд нь “Зүрхний саажилт” гээд биччихсэн. Дмитрий Дмитриевич тэр дүгнэлтэд гарын үсэг зурахаас татгалзсан. Өөрөө надад энэ тухай ярьсан юм. Ингээд хүсэмгүй гэрч болсон учраас одоо түүнийг цааш нь харуулж байна. Эхлээд хүчирхийлэгч гэж гүтгэн доромжилсон, тэгтэл одоо алуурчин болгож байна.

– Үгүй, тэр чинь бүгдий нь хүлээн зөвшөөрлөө шүү дээ.

– Эрүүдэхгүй юу, тэгээд л хүлээж таараа. Та нарын тэр шүүх хурал дээр чинь тэд цөмөөрөө хэргээ хүлээцгээж байгаа шүү дээ.

Вадим эсэргүүцэн тунтаганав.

– Яг тийм шүү! Битгий татвалзаад бай! Чухамхүү та нарын тэр шүүн таслах хурал дээр. Та нар Лубянкийн зооринд эрүүдэн тарчлааж л хэрэг хүлээлгэж байгаа. Танай ялт засаг...

– Эцэг, эцэг, болиоч! хэмээн Вадим хашгарлаа.

Андрей Андреевич суларсан зангиа нь хоолойг нь боогоод байгаа мэт түүнийгээ оролдон, толгой сэгсэрч,

– Ялт засаг... Ялт засаг... хэмээн давтан хэлэв. – Та нар цөмөөрөө гэмт хэрэгтнүүд, зандалчид... Чи ч гэсэн... Чи ч бас гэмт хэрэгтэн... Чиний өгүүллүүд бузар, жигшүүртэй, чи журамт хүмүүсийг мөшгиж, устгаж байна... Энэ ялт засаг чамайг худалдаж авсан... Би мэдэж байна...

Ээ бурхан минь, одоо нөгөө “Вацлав”-ын тухай хэлэх нь. Үгүй, үгүй, хэрхэвч хэлүүлж болохгүй!

Вадим,

– Тэд нар чамайг худалдаж аваагүй юү?! гэж хашгарлаа. Өвгөн гайхахын дээдээр гайхан түүн рүү харав.

– Хэн... Чи чинь юу ярьж байна аа?!

– Чи чинь тэдэн дээр очдог, тэднийг эмчилдэг шүү дээ. тэд нар чамайг эрхлүүлдэг, хүмүүст идэх юм юу ч байхгүй байна, гэтэл чамайг элдэв хүнсээр дардаг биз дээ гэснээ Вадим тавгаа түлхэв. – Энэ тахиа хаанаас ирэв?! Тэднийхнээс! Тийм ээ, би алба хааж байгаа, гэхдээ би бол үзэл санааны төлөө алба хааж байна, харин та бол тахианы махны төлөө алба хааж байна гээд мань эр дахиад тавгаа түлхэв. – Ард түмний хүзүүн дээр мордчихоод, тэднийгээ бузар бургтаар булж байна. Горький та нарын төлөө бүхнийг хийсэн, та нарт туслаж байсан, та нарыг аварч байсан. Чамд энэ байрыг хэн хөөцөлдөж өгсөн? Горький! Гэтэл та нар ачийг нь юугаар хариулсан билээ? Горькийд хор өгсөн...

Андрей Андреевич ганц үг ганхийх тэнхэлгүй, ангалзан агаар залгиж, Вадим руу хоёр гараараа савчин байв.

– Тийм шүү, би өөрийнхөө чихээр сонссон. Энд, энэ өрөөнд та нар: “Театр, гудамж, хотыг Горькийн нэрэмжит болголоо, одоо зөвлөлт засгийг Гашуун засаг гэж өөрчлөн нэрлэх хэрэгтэй” гэж хөхрөлдөж байсан. Сонссон, мэдэв үү, би биечлэн сонссон! Намайг одонгоор шагнуулахад чи баяр ч хүргээгүй, тэгсэн мөртлөө чамд шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол олгоход хүлээн авалт хийж тэмдэглэсэн, өөрийнхөө шагналыг бахдан хүлээж авсан, тэгсэн чинь би болохоор хүний шаар, өчүүхэн новш юм гэнэ. Гүйцээ, больё чиминь! Чиний намайг юу үзэж байгааг би мэднэ. Чи Викаг гэсэндээ тэр Нелла Владимировна гэдэгтэй хошуу холбосоор байгаа, гэтэл Вика гадаадын тагнуултай суусан, чи үүнийг нь харсаар байтал сайшааж байна. Чи энэ жил гадагшаа явна гэж байгаа, Викатай уулзана, тэгээд тэр чинь нөхөр шуу юмнаасаа ямар нэг тагнуулын даалгавар авч чамд өгнө, гэтэл чи түүнийг нь тэнэгтээ болж дуртайяа биелүүлнэ. Тэгээд, чи бид хоёрыг гадаадын тагнуул гэж нэг шөнө баривчлахаар ирцгээж таарна гэсэн аюул заналын дор би амьдрах ёстой болно. Тэгэхгүй шүү! Тийм аюул заналын дор би амьдрахыг хүсэхгүй байна! Зөвлөлтийн эсрэг яриаг би өөрийн эцгээс ч гэсэн сонсохыг хүсэхгүй байна! Хүсэхгүй! Үүнээс би залхаж байна! За-ал-хаж байна! Байраа салгаж сольё гэж би чамд аль хэзээ хэлсэн, чи дургүйцээд байсан. За тийм байж, тэгвэл би өөрөө хийнэ, надад тэгэх эрх бий, хууль миний талд байгаа. Байраа солихыг эсэргүүцэхгүй байхыг би чамд зөвлөж байна! Тийм, зөвлөж байна! Бид нар яагаад хамт амьдарч чадахгүй болсон тухай намайг шүүх дээр үнэнийг ярихаас өөр аргагүй битгий болгоорой.

түүнийг ийнхүү ярьж байхад Андрей Андреевич зангиагаа базлан, толгой сэгсэрч, ямар нэг юм хэлэх гэж оролдон байсан боловч “чи..”, “чи...” гэхээс өөр юу ч хэлж чадахгүй байсаар эцэст нь чимээгүй болж нүдээ анилаа. Толгой нь хажуу тийшээ унжаад ирлээ... Вадим босон харайж, эцгийгээ түшиж авав. Өвгөн дахиад ам нь ангалзан агаар залгиж, өрөөсөн нүдээ нээх төдий болоход харц нь гөлөрчихсөн байв. Нүдээ дахиад анилаа. Вадим түүнийг арайхийн чирч аваачиж, буйдан дээр хэвтүүлээд, дэр хийж өгч, шаахайг нь тайлаад, бүтээлгээр хучив.

Андрей Андреевич нүдээ аниастай чигээрээ хэвтэх зуур нэг бол амаа ангалзан арайхийн амьсгалж, нэг бол амьсгаа авахгүй байгаа мэт таг чимээгүй болж байв.

“Түргэн тусламж” дуудах хэрэгтэй.

Гэхдээ зүрх нь гойдгүй болохоор эцэг нь нэг бус удаа ингэдэг байсан, харин “түргэн” дуудахыг зөвшөөрдөггүй, яаж ийгээд болдог байсан билээ. Жаахан хэвтээнэнэ, бамбайн ханд ч юм уу, өөрт нь байдаг элдэв дулаас нэг юм уучихна. Одоо ч гэсэн ингээд зүгээр болно... “Түргэн тусламж” хүрээд ирнэ, эцэг тэр үед босчихсон байна. Эвгүй, улсыг дэмий түйвээж, машин дэмий давхиулсан хэрэг болно.

Эцэг нь нүд аниастай хэвтэнэ. Вадим тонгойж чагнавал амьсгалж байх шиг! Гарынх нь судсыг баахан тэмтэрч байж оллоо. Ээ бурханы аврал гэж, зүгээр болох нь. Хөөрхий муу эцэг. түүнийг юу хүлээж байна вэ? Орчин үеийн амьдралд хөлөө олохгүй байна, баригдана, шоронд орно, зовж тарчлана, шившиг болно, өөр зам алга. Эцгийг нь баривчилвал Вадим сүйрнэ, тэр сүйрэл хэзээ ирэхийг хүлээн аж төрж чадахгүй, эцэг нь түүнийг гэнэт “Вацлав” гэх юм бол тэсэхгүй. Вадим утас руу очиж, харилцуураа авч дохиог сонсоод буцааж тавив. Элдэв бодол толгойд нь үймнэ.

Ээ тэнгэр минь, яадаг хэрэг вэ, яахав? Цаг тутам, өдөр тутам, шөнө тутам сүйрэл хүлээн яаж аж төрөх вэ? Эцэг нь баривчилгаа руу өөрөө зүтгэлээд, өнөөгийн нөхцөлд журамт ёс, жудаг мэтийн ойлголт байх ёсгүйг ойлгохгүй юм.

Гэтэл энэ хөдөлсөн өвчин нь зүгээр болохгүй бол яах вэ, энэ нь хуучин болдогоос нь шал өөр юм байвал яах вэ?!

Вадим утсаа авч, “03”-ыг эргүүлвэл ярьж байна.

Энэ хөгшчүүл яагаад ингэж хувиа бодомхой байна аа? Өрөөсөн хөл нь авсанд байхад үхлээс айхгүй шүү, за яахав, айхгүй л бай л даа, гэхдээ бусдыг араасаа авс руу битгий чир л дээ! Хүүгээ өрөвдөөч, эцэг минь! Хүү чинь чухамдаа амьдарч эхлээгүй байна шүү дээ! 28 чинь нас юм уу?.. Үгүй ээ, би өөрийгөө хөнөөлгөхгүй, эцэг, уучлаарай, хөнөөлгөхгүй, заяа нь үгүй! Ээ тэнгэр гэж, яадаг хэрэг вэ, одоо яахав?

Вадим цагаа харвал найм хагас болж байна. Феня орой Феоктистовынхныд очихоороо ер нь бол арав гэхэд эргээд ирдэг.

Вадим халуун усныхаа өрөө рүү орлоо. Хананд өлгөөтэй жижигхэн хайрцагт буй гэрийн эмийн сангаас бамбайн хандны дусал олж, он сарыг нь харвал ноднингийнх аж. Хаявал таарах эд. Гэвч түүнийг халааслаад хоолныхоо өрөөнд эргэж ирснээ, буйдан руу очиж эцэг рүүгээ тонгойлоо.

– Аав аа!

Эцэг нь хариу дуугарсангүй. Нүүр рүү нь тогтож харвал сормуус нь хүртэл эрвэлзэхгүй байх аж. Гарыг нь өргөж үзвэл, хүйтэн байна, буцаагаад тавьсанд шал шүргэн эзэнгүй мэт уналаа.

Дугхийсэн юм болов уу? Тэгвэл сайн шүү, нойроо авчихаар бүх юм зүгээр болно. Вадим агаар орог гэж цонхны салхивчийг онгойлгов. Мэдээж бүх юм гайгүй өнгөрнө. Санаанд зурсхийсэн нэг юм бол зүгээр л тэнэглэл, энэ тухай бодохын хэрэг байхгүй, болох юм л болно биз. Харин мань хүн бол энэ зуур эмийн сан ороод ирнэ. Хуучин эм хэрэггүй учраас өөрөө шинэ эмэнд явж байгаа нь тэр.

Вадим эмийн сан орох замдаа халаасандаа байсан бамбайн хандыг тэмтэрч, бөглөөг нь тэндээ эргэдэж онгойлгоод, гаргаж ирж атгаж байгаад, тэр шингэнийг хаврын шавартай цас руу асгачихав. Өнгөрсөн оны хуучин ханд, тэртэй тэргүй хэрэггүй эд, гэхдээ асгаж байгааг нь хүн харах ёсгүй, юу ч гэж тэнэг юм бодож мэднэ. Ажлаасаа гэр өөдөө яаран яваа санааширсан, ядарсан хүмүүс замд нь тааралдаж байна. Арбатад танихгүй хүн яасан олон болоов дээ. Бүх юм урсан өнгөрөх юм. Бас бүх юм урсан одох юм. Нэгэн цагт ээж нь энд явж асан, ээж нь байхгүй болоод удаж байна. Вика явж байсан, ашгүй, Москвад дахиж ирэхгүй, үсчин Сергей Алексеевич явж байсан, тэр ч бас үүрд алга болсон, бас Саша Панкратов Сибирь рүү тонилсон, бас Юрка Шарок харагдахаа больж – өөр хотод шилжүүлсэн, үгүй бол буудан хороосон ч байж магадгүй, тэдний ажлынхантай ч нэг их нэрэлхэж цэрвээд байх биш, Лена Будягинаг цөлчихсөн, Нина Иванова бас алга болчихсон, бүгдий нь тараагаад хийсгэчихсэн, хэн ч алга. Эцэг нь ч явж одно. Вадим өөрөө ч цаг нь ирэхээр бас явж одно. Бүх юм болзмол, бүх юм түргэн зуурынх, жилээр наана, жилээр хойно уу л гэхээс, түүхэнд бол хүний амьдрал ердөө ганцхан хором. Вадим Арбатын булан дээр хандныхаа гожоохойг тантан руу сэмхэн хаяв.

Вадим эмийн сангийн оочирьг тэвчээртэй зогсож барав. Кассчин, худалдагч хоёр хоёулаа танил хүн байна. “Эцэг зүрх гээд байна, зүрхний ямар нэг юм өгнө үү”. түүнд бамбайн ханд, бас Вотчелийн дусал өгсөнд тэрээр талархал илэрхийлэхдээ, ийшээ ирсэн нь сайн болж, өөрий нь хүмүүс харсан нь сайн болж гэж гэнэт боджээ. Яагаад тэгж бодсоныг бүү мэд, ямар ч гэсэн тэгж бодож. Одоо ингээд харина. Эцгийнх нь бие гайгүй болсон байлгүй, эмийн сангаас авсан эмээ үзүүлнэ. Халуун усны өрөөнд харсан чинь юм олдсонгүй, эмийн сан руу харайлгаад ирлээ, май уу, гол нь сэтгэлээ бариарай, юугаар төгсдөгийг харлаа шүү дээ гэнэ...

Андрей Андреевич түрүүчийнхээ янзаар хэвтэж байв. Вадим түүнийг дуудсан боловч хариу алга. Дээрээс нь тонгойвол амьсгаа нь сонсодсонгүй, гарыг нь өргөөд буцаагаад тавихад, бас эзэнгүй мэт шалан дээр уналаа.

Вадим “03” руу залгаад, профессор Марасевич рүү “түргэн тусламж” нэн даруй ирүүлэхийг шаардлаа. Өвчтөн яагаав? Зүрхээр нь хатгаад. Хаяг? Вадим хаягаа хэлэв.

Хорь орчим минутын дараа дамнуургатай хоёр сувилагч дагуулсан, пальтоныхоо гадуур цагаан халаад хэдэрсэн залуу эмч орж ирэв. Сувилагч нар ч халаадаа пальтоныхоо дээгүүр өмссөн байж.

Феня бараг тэр үеэр ирж, байж суух газраа олж ядан үглэж гарав. Вадим түүнийг зандарлаа. Эмч Андрей Андреевичийн хавьд буйдан дээр суугаад, судсыг нь барьж, зүрхийг чагнаж, зовхийг нь нээж энэ тэр баахан үзсэнээ босов.

– Үхсэн хүнийг бид авч явдаггүй.

Ханын дагуу байрлуулж, толгой дээр нь нүүр гарын алчуур тохсон хоёр төмөр ор, бүтээлэггүй ганц ширээ, дөрвөн сандал, сав суулга бүхий гал тогооны шүүгээ. Хувцас хунараа хананд шаасан хадааснаас өлгөжээ. Хүүхдийн ор байхгүй бол энэ умгар өрөө оюутны дотуур байрыг санагдуулам аж.

– Бидэнтэй манай хуучин үйлчлэгч байсан Маша цуг байдаг юм, одоо үйлдвэрт цэвэрлэгч хийж байгаа, амрах өдрөө манай хүүхдийг харна, би элдэв байгууллагаар хэсүүчлэнэ гэж Лена учирлав.

Ийм хариугүй гуйланч байдлыг Варя хараахан үзээгүй яваа билээ. Ядуус хаа сайгүй байгаа, гэхдээ тэр байдал бол олон жилийн, ижил дасал болсон, хүмүүс зохицчихсон ядуурал. Ленагийн хувьд бол гуйланчлал гэнэт нөмрөөд ирсэн – байрнаас нь гаргаж хаясан, ажлаас нь хөөсөн, тоносон, дээрэмдсэн, амь зуух ямар ч юмгүй болгосон.

Лена дэлгүүр явах санаатай, Ваняг хувцаслахад, Варя оронд нь яваад ирье гэв.

– Их оочиртой.

– Хүүхэдтэй бол оочиргүй оруулах уу?

– Одоо оочиргүй оруулдаг хүн бий сэн билүү?

– Би зогсоход яахав дээ.

– За, тэг, баярлалаа, май мөнгө, хоёр шил тараг аваарай.

– Өөр ямар нэг юм хэрэгтэй биш биз?

– Үгүй чиш, өөр юу ч хэрэггүй.

Варя тарагнаас гадна цөцгий, хэдэн хайлмал бяслаг, арваад өндөг, гурван зуун грамм бүржмэл чихэр авав.

– Чи биднээр найр хийлгэх нь үү? гэж Лена буруушаангуй толгой сэгсэрч, – Дараа битгий ингээрэй. Надад эвгүй байна гэв.

– Дараагийн тухайд харан байж болоё гээд Варя инээмсэглэв.

Ваня майгадуу хөлөө инээдтэй майхгануулсаар эх рүүгээ ирж, банзлынх нь хормойноос зуурч авав. Хөөрхөн цагаан хүү (Шарок л юм даа гэж Варя бодов) өөр рүү нь цэнхэр нүдээ бүлтийлгэн харж байна. Лена хүүгээ сэгхийтэл өргөөд ширээ рүүгээ суув.

– Манайхыг гурван удаа нэгжсэн гээд Лена тарагнаас аягалаж, хүүдээ хэрчим талх атгуулаад, духан дээр нь үнсэв. – Нэг нь Грановскийн гудамжны байранд, аавыг баривчлах үед, нөгөө нь зуслан дээр, гуравдахь нь энд, ээжийг барих үеэр. Хамаг юмыг маань хуу авсан – мөнгө, үнэт

эдлэл, зээлийн сугалаа, ном судар гээд. Миний хэдэн даашинз, аавын костюмнуудыг бас, бүгд гадаадынх юм чинь яаж орхиж болохов дээ? Хоёр өрөөг шууд битүүмжилсэн, тэнд байсан бүх юм тэр даруй алга болсон – аав, ээжийн баримт бичгүүд, эгшигт хайрцаг, тэр ч бүү хэл, Владлений унадаг дугуй хүртэл алга болсон. Зайлшгүй хэрэгцээтэй зүйлийг буцааж өгөөч гэж би өргөдөл бичсэн, хэн ч хариу өгөөгүй. Нэгжлэгийн дараа, “Гарын үсэг зурахгүй бол юу ч үлдээхгүй” гэж сүрдүүлж байгаад, ДЯАК-д ямар ч гомдол байхгүй гэсэн бичигт албадан гарын үсэг зуруулсан. Харсаар байхад хамаг юм тонож байгаа юм чинь, чемодан савны цоожыг эвдлээд л. Босоо шүүгээг хүртэл аваад явчихсан, хөөрхий муу шүүгээ хүртэл зөвлөлтийн эсрэг юм байх нь л дээ.

Лена хүүгийнхээ духан дээр дахин үнссэнээ Варя руу духайсхийн харлаа.

– Аавыг баривчлангуут миний орон тоог цомтгоод ажлаас шууд хөөсөн, долоо хоногийн дараа тэр орон тоог сэргээгээд өөр хүн авсан байна лээ.

– Ингэхэд, чи ямар ажил хийж байсан юм бэ? Варя түүнтэй бас чи гэж харьцахаар шийджээ.

– Англи хэлнээс орчуулна. Бас францыг ч мэднэ. Даанч авахгүй юм. Долоо хоногийн дараа утасд, тэгснээ дахиад долоо хоногийн дараа гэнэ, нэг этгээд бүр: “Овгоо соль” гэсэн шүү. Шал, жорлон угаадаг шөнийн цэвэрлэгчийн ажилд орох гэсэн чинь тэгж байгаа юм, бод доо. Шуудан зөөгч хэрэгтэй гэсэн нэг зарлал харлаа. Надад болох ажил, захидал, сонин хэвлэл тараахад яахав, Владленийг сургуульдаа явтал Ваня эрхбиш хүнтэй байх юм чинь. Очлоо. “Өргөдлөө бич, маргааш, өглөөний зургаа гэхэд ир” гэгцгээж байна. Маргааш нь очсон чинь нөгөөдүүл чинь газар шагайчихлаа. “Уучлаарай, хүн орчихсон”. Хэд хоногийн дараа харсан чинь нөгөө зарлал хэв хэвээрээ байж байна. Тэглээ ч гэсэн би яваад л байгаа... ДЯАК руу ч очно, Кузнецкийн 24 тоот руу ч очно, прокурор руу, бас цэргийн прокурор руу очно, аавыг шоронгоор хайна, ээжийг... хэний нь ч олоогүй, “захидал харилцааны эрхгүйгээр” ялласан, тэгэхээр тэд одоо нэгэнт байхгүй болсон гэсэн үг... Байхгүй гээд л хэлчихвэл болоо шүү дээ, гэтэл шоронгоос шорон руу, цонхноос цонх руу хөөж, улс амьтныг зовоож байх хэрэгтэй юм гэнэ!

– Энэ чинь надад танил зүйл.

– Тийм үү? Танайхаас хэн нэгнийг баривчилсан юм уу?

– Саша Панкратовг эргэлт хүргэдэг байсан юм.

Ленагийн царай барайгаад явчихав.

– Сашагийн өмнө бид бүгдээрээ буруутай, тэгэхэд түүнд туслаагүй...

– Та нар юу хийж чадах байсан юм бэ?

– Чухам юуг мэдэхгүй, гэхдээ л хийх ёстой байсан юм. Нөхрөө хамгаалаад, захидал, өргөдөл бичээд, ДЯАК-аар, прокуророор яваад гэх мэт. Тэгэхэд дөнгөж эхэлж байсан. Гэтэл бид дуугай байгаад байсан. Одоо түүнийхээ горыг эдэлж байна. Би ч, миний эцэг ч, Сашагийн

нагац ах ч, мянга мянган хүн, сая сая хүн горьг нь эдэлж байна.

– түүнээс эрт эхэлсэн – хамтралжуулалтаас, нударганчуудтай тэмцсэнээс эхэлсэн.

– Өө тийм дээ гээд Лена хүүгээ буулгав. – Гэхдээ би тэр үед гадаадад амьдарч байсан болохоор энэ бүхний чинь талаар юу ч мэдэхгүй явж. Харин Сашагийн явдал бол миний нүдэн дээр болсон. Ийм юм манийг хавирна гэдгийг бид мэдэхгүй байж. Тэгээд одоо би надаас нүүр буруулж байгаа улсыг харахаараа, та нарт ч ийм явдал тохионо, тэр цагт та нар зайлсхийж явсан хүмүүсээ санах болно доо гэж боддог юм. Энэ гурван жилийн, нарийндаа бол дөрвөн жилийн хугацаанд би Сашагийн ээж дээр нэг ч удаа очоогүй шүү дээ. Бусдын зовлонд хавьтахыг хүсэхгүй, өөрийн амар тайвныг бөөцийлж яваад, тэгснийхээ төлөө цээр хүртлээ. Ийм л бодол толгойд орж ирэх юм байна шүү дээ, Варенька минь. Ичмээрээ ичмээр.

– Дурсахаас ичмээр юм хүн болгонд бий гэж Варя өгүүлэв.

Лена санаа алдаж цагаа харснаа Варя руу харав.

– Одоо Владлен сургуулиасаа ирнэ. Би чамд урьдчилж нэг юм хэлмээр байна. Тэр маань арван гуравтай, суртал ухуулгын нөлөөнд бүрмөсөн авгчихаад байгаа, Бухарин – Рыковын шүүх хурлын бүх тайланг сониноос уншчихаад, үг болгонд нь үнэмшиж, яллагдагсдыг зүхэхдээ, тэднийг араатан шиг торонд хийж байлгах хэрэгтэй, хүмүүс тэдэн рүү нулмилж байг гэж ярина. Аав, ээж хоёрыг бас зүхэж: “Тэд нар чинь бас л Бухарин, Рыковтой нэг үг” гэнэ. Нисгэгч болохыг мөрөөдөж байсан, хэдийгээр нисэх төхөөрөгийн загвар зохиогч, энэ чиглэлээр авьяастай хүү ч гэсэн мань хүний нисгэгч болох одоо өнгөрсөн, загвар зохиогчдын тэмцээнд оруулаагүй, өөрийгөө шоовдор хүн гэж мэдрээд бүх юман дээр аав, ээж хоёрыг буруутгаж байгаа. Сургууль дээрээ хүртэл тэднийг буруушааж үг хэлсэн гээд л бодчих.

– Тэгж байгаа анхны хүүхэд тэр биш.

– Тийм л дээ, гэхдээ би бас өөр хүүхдүүдийг мэднэ. Манай эцэг эхчүүд үзэл санааныхаа төлөө тэмцэж байсан. Хожим бүх юм цусанд хутгалдана... гэж хэн мэдэх вэ дээ... Гэтэл би үүнийг Владлений толгойд ойлгуулж чадахгүй байна. Эцэг, эхийнхээ алийг нь ч өчүүхэн төдий өрөвдөж байгаа юм алга. Ингэхэд, эцэг эх маань ч хүүхэд биднээсээ хөндий байсан, нам, улсынхаа ажлаар хөөцөлдөөд бидэнд зориулах цаг хүртдэггүй байсан гэснээ, шоогоор тоглож буй хүү рүүгээ зааж,

– Хэний хүү гэдгийг нь гадарлаж байна уу? гэв.

– Юра Шарокийнх.

– Нэр төргүй, аймаар муухай холбоо, миний хүнд алдаа хэмээн Лена Варяг эгцлэн харж тайван өгүүлээд, – гэхдээ бас бус юмныхаа хажуугаар тэр юугаараа намайг татсан гэж бодож байна? Хичнээн хачирхалтай хэдий ч гэр бүлийнхээ байдлаар шүү гэв.

– Нээрэн үү? Тэднээс муухай улс би үзээгүй... гээд Варя дал мөрөө хавчив.

– Одоо бол би ч ойлгож байна. Гэтэл тэр үед бол манай гэр бүлээс эрс ялгаатай, эв найртай, бат барилдлагатай, жинхэнэ гэр бүл гэж надад санагдсан юм. Харин манайх бол... Дөрвүүлээ хамт суугаад хоолоо идэж байсан удааг би санадаггүй юм, цөмөөрөө өөр өөр цагт хооллож таарна. Бид тэгж л өссөн... Владленаас эцэг, эхийн тухай битгий асуугаарай, улс төрийн тухай битгий яриарай, аливаа өсвөр багачуудын адил итгэл үнэмшилдээ нүгэлтэй үнэнч.

Варя толгой дохиж,

– За, бодолцоё гэв.

Хашаан дотроос дуу чимээ гарав. Лена цонх руу очсоноо, Варяг хуруугаараа дохин дуудав.

– Энэ байшинд өдөр болгон ийм явдал болдог юм.

Тэдний орцны хавьд дөрвөн ачааны машинаас юм буулгаж байгаа нь шинэ айл нүүж ирж байгаа юмсанж. Аюулаас хамгаалахын дүрэмт хувцастай, ташаандаа гар буутай бүдүүн нөхөр, хашгачиж гуугачсан эхнэр, долоо-найман насны хоёр шар толгойтой охин. Аюулаас хамгаалахын ажилтан эд хогшлынх нь уяа боодлыг тайлж байгаа арваад ачигч нарыг зэрлэгээр захиран хашгачиж байна.

– Манай шүүгээ, ширээ, буйдан энэ тэр бүгд сангийнх байсан, цөмөөрөө эд хөрөнгийн бүртгэлийн шошготой. Хүмүүс нэг их эд хогшил гээд байхгүй. Гэтэл эднийхний тавилга цөм эртний хийцнийх: толь, ширээ, шилэн нүүртэй шүүгээ, тохойвчтой зөөлөн сандал, төгөлдөр хуур!

– Бүгд хулгай дээрмийнх. Надад одоо пулемет байсан бол би эднийг нэгд нэгэнгүй шүршээд, чөтгөр шулам руу нь тонилгох байсан! гэж Варя цухалдав.

– Варя, хэзээ ч ийм юм битгий ярьж бай, хэзээ ч, бас хэнд ч, бүр хамгийнхаа дотны хүнд ч битгий ярьж бай.

– Гойд юм юу байна? гээд Варя мушилзав. – Би ачигчдыг л хэлж байна. Манай эрэлхэг аюулаас хамгаалахын ажилтныг олигтойхон үйлчилчихэж ч чадахгүй шүү?!

– Бүр ачигчдын тухайд ч тэгж битгий ярьж бай.

– За яахав, дуугай болцгооё.

Владлен сургуулиасаа ирж, Варятай баргар царайлан мэндлээд, сэмэрхий бэржээхэн цүнхээ орон дээр хаялаа. Лена түүнд үдийн хоол гэж байцааны усан шөл, шар будааы зутан өгөв. мань хүү идчихээд, баярлалаа ч байхгүй, хэзээ ирэхээ ч хэлэлгүй яваад өгөв.

– Энэ Владлены талаар ямар нэг шийдвэр гаргах хэрэгтэй байна хэмээн Лена сүүрс алдав. – Өнгөрсөн долоо хоногт манай байшингийн наян таван айлыг Москвагаас цөлсөн. Юу болсон гээч! Ёстой таллага! Арай л дэрнийх нь өдийг сэгсчээгүй байх. Хашаагаар дүүрэн аюулаас хамгаалахынхан, хүн, чемодан хоёрыг ялгахгүй машин дээр шидлээд л. Дахиад жаран айлын жагсаалт гаргачихсан гэсэн яриа байгаа, тэдний дотор би байгаа байх. Шинэ газар очоод би

Владленийг яах болж байна? Би энд ч түүнийг олигтойхон хооллож чадахгүй байна, хүүхэд том болж, бие махбод нь хоол нэхэж байна. Гутал нь урагдчихсан, шинийг юугаар авах сан билээ? Зарж борлуулах юм юу ч алга. Миний байгаа бүх юм энэ өмссөн маань. Владленийг өнчин хүүхдийн газарт өгнө гэж бодохоос гол харлах юм, гэхдээ өгөхөөс өөр замгүй болох нь. Дүүргийн захиргаан дээр очсон чинь Даниловский вал-ын ДЯАК-ын хүүхэд хувиарлах газар оч гэсэн, гэтэл тэр бол аймшиг, чухамдаа хүүхдийн шорон.

– Тэндээс чинь өнчин хүүхдийн газар руу хувиарлана, харин тэр газар нь бол арай танагтай.

Лена дахиад сүүрс алдав.

– Бусад хүн ч бас тэгж ярих юм. Манай байшингийн олон эх цөллөгнөөс өмнө амжиж хүүхдүүдээ тийш нь өгсөн. Владленийг өгч таарах нь, өөрөө ч хүсээд байгаа юм. Нэг удаа огт идэх юмгүй байсан чинь тэрний адармаа хөдлөөд миний тэвчээрийг барсан. Тэгээд: “Өнчин хүүхдийн газар өгнө дөө, тэнд л чамайг сайхан хооллоно” гээд хэлчихсэн чинь, “Маш сайн байна. Үгүйдээн энэ хараал идсэн овогноос сална” гэж хариулсан шүү.

– Чамайг хөөвөл Ваня яах болж байна аа? гэж Варя асуув.

– Надтай л цуг байна. Би яаж ийгээд ажилд орно, эд нар чинь биднийг арай өлсгөж алахгүй байлгүй.

– Чи ажиллаа гэхэд хүү чинь хэнтэй байх хэрэг вэ?

– Харин нь ээ... Би хүүхдээ хаяж чадахгүй шүү дээ! Яахав, хоёулаа л үхэхээс. Зарим айлд цөлөгдөх хотоо сонгохыг зөвшөөрсөн, би бол алийг сонгохоо мэдэхгүй юм. Холын хамаатны улс Бакуд, Мотовилихт бий, гэхдээ би тэднийг танихгүй, хаягий нь хүртэл мэдэхгүй. Нэмэрт нь одоо чинь хүмүүс юм болгоноос айна... Заримдаа унтчихаад сэрэхгүй байх юм сан, энэ хар дарсан зүүд шиг юм руу эргэж ирэхгүй байх юм сан гэж санагдах юм.

– Ямар ч гэсэн чамд хот сонгох боломж олговол Мичуринск гэж хэлээрэй, тэнд манай хамаатны нэг эгч бий, өтөлсөн, гэхдээ бас ч гэж сэргэлэн, маш сайхан сэтгэлтэй авгай, ганцаараа байдаг юм, чи тэднийд сууж болно. Мичуринскийг өгөхгүй бол Уфаг гуйгаарай.

– Яагаад Уфа гэж?

– Яагаад Уфа гэж үү? хэмээн Варя давтан өгүүлээд, – Юу л даа, Саша суллагдсан шүү дээ гэв.

– Өө тийм үү?

– Хугацаагаа дуусгасан, гэтэл том хотуудад суух эрх байхгүй. Уфад жолооч хийж байгаа, Софья Александровна түүнд захиагаа “өөрөө хүлээн авагч” гээд явуулдаг юм, чи ч гэсэн очихоороо “өөрөө хүлээн авагч” гээд ил захидал явуулчихгүй юу.

Лена бодолхийлснээ толгой сэгсрэв.

– Энэ ч болохгүй ээ. Саша ял эдэлсэн, би “ардын дайсны охин”, түүний байдлыг улам

яршигтай болгочихно. Надад тэгэх эрх байхгүй. Хэрэв надад сонгохыг зөвшөөрөх юм бол Мичуринск нь дээр юм байна, галт тэрэгний буудлаас очиж, анхны шөнийг ч болохноо өнгөрүүлэх айл байх нь. Гэхдээ надаас хаашаа явах хүсэлтэйг бараг л асуухгүй байх, цөлөөд л гүйцнэ.

– Юмыг яаж мэдэх вэ, асуух юм бол гэж Варя зүтгэв.

– Тэгвэл Мичуринск гэе, гэхдээ эгч авгай чинь хүүхэдтэй хүнийг хүлээж авах болов уу, үгүй болов уу?

– Гарцаагүй хүлээж авна. Би захиа биччихнэ.

– За чамд баярлалаа. Энэ чинь надад их нэмэр болно.

Саша, Глеб хоёр голдуу ресторанд хооллоно. Үнэ нь гуанзныхаас нэг их биш, илүүтэй нь шөнийн арван хоёр хүртэл суусан ч болно. Заримдаа яггүй балгана. Глеб энэ тухайд сурчихсан хүн, Саша зугуухан дасч буй. Маргааш юу болох нь бүү мэд болохоор үгүйдээн өнөөдрийг мөрөөрөө өнгөрөөх нь чухал. Глеб нэг удаа,

– Өнөөдөр энэ ресторанд манай даргыг чи харна шүү гэж хэлжээ.

– Мария Константиновнаг уу?

– Москвагаас нэг чухал авгай ирсэн, Машкагийн танил хүүхэн. Тэгээд мань хүн л түүнд зориулж хүлээн авалт хийж байгаа хэрэг, мэдээж, Семёний мөнгөөр. Нонка ч тэдэнтэй цуг байна.

– Чи бид хоёр үхсэнээ хийх гэж тийшээ зүтгэлэх билээ?

– Тэд нар өөрсдийнхөө мөрөөр, бид өөрсдийнхөө мөрөөр байхгүй юу, ялдам минь. Тэд нар шарсан шабмаг зална, чи бид хоёр бол май загасаар даруулан нанчидаа хүртэнэ.

Саша, Глеб хоёр сурсан зангаараа рестораны нэг мухарт сууцгаав. Семён хамт яваа хүүхнүүдтэйгээ танхимын голд тухлан, тэднийг тойрон дарга хүүхэн тэргүүтэй үйлчлэгч нар хөлхөлдөн бүхийг харваас зочдоо эрхэм хүмүүс гэж үзэж байгаа нь илт.

Сашагийн суудлаас тэд нар тодхон харагдаж байв: Семён, Нонна, өөр хоёр хүүхэн. Глебийн хэлсэнчлэн хар үстэй нь Мария Константиновна, нөгөө хонгор шар үстэй, биерхүү хүүхэн нь Москвагийн том дарга болж таарах нь. Сайхан хувцасласан, тордлого сайтай, гуч эргэм насны гоё хүүхнүүд өөрийн эрхгүй хараа булаана. Найрал хөгжимчид элдэв киноны хөгжим тоглож, харин дуучин хүүхэн цыган романс эс дуулах аж.

– Энэ авхайгаас болж зөвхөн Дунаевский, Блантер хоёрын аяыг дарж байна, үзэл суртлаа барьж байгаа нь тэр. Харин хүүхнүүдийн хувьд ч арааны шүлс асгам дамшгууд байна шүү! гэж Глеб өгүүлэв.

Семён Григорьевич эргэж мань хоёр руу харахад тэдний харц мөргөлдсөн боловч гэмгүй царайлцгаав. Семёнийг дагах мэт хоёр авгай ч эргэж харцгаалаа.

– Семён багийнхаа бүрэлдэхүүнийг харуулж байна хэмээн Глеб Саша руу нүд ирмэв. – Машка ч ёстой лут хүүхэн дээ, баргийн эрийг хавьтуулахгүй, би ойртох гэж үзээд шууд хөөгдсөн шүү. За тэр Семён өөрийнхөө барааг, өөрөөр хэлбэл, чамайг, би ийм сайхан дээд боловсролтой, оюунлаг туслахтай, Москвагийн хүн гэхчлэн магтаж алдаж байна. Энэ хоёр хүүхэнд ая тал засаад сүйд. Ингэхэд, тэр Москвагаас яваа чинь Төв Хорооны театр хариуцсан зааварлагч, ланжгар дарга. Машкатай цуг сурч байсан юм. Машка Москвад татах хүнтэй, хэрэг болвол аврана гэж ийм зоригтой байдаг юм. Москвад ийм татаастай байх сайхан аа даа?

– Бодвол муугүй байх...

– Мундаг гар. Надад тусалъя гэх юм бол нүд ирмэхийн зуур зохицуулчихна. Мэдээж, өөрсдийнхөөрөө, ТХ-ныхоо аргаар, утсаар зохицуулчихна: “Бид энд зураач Дубинины бүтээлийг харлаа. Сонин бүтээлүүд байна” гэчихнэ. Харж байгаа биз, ялдам минь, үнэлгээ байхгүй, зүгээр л сонин бүтээлүүд гээд л гүйцээ. “Нэг бодол байгаа”. Ойлгов уу? Шийдвэр бус ердөө л нэг бодол. “Нөхөрт туслах хэрэгтэй” гэчихнэ. Тэр нь тэднийхнийхээр бол албан ёсоор бус хүнлэг ёсоор гэсэн үг. Товчдоо, “Танай театрын ерөнхий зураачийн албан тушаалд томилуулахаар Глеб Васильевич Дубининг явуулж байна” гэчихнэ. Тэгээд авчихна гэж мэд, ганц үг ган хийхгүй.

– Чи ч жүжигчин байх хүн дээ!

– Надад чадахгүй юм байхгүй ээ, ялдам минь!

Маргааш нь хоёр хүүхэн Семён Григорьевичийг бараа болгосоор Хөдөлмөрийн ордонд ирлээ. Пальтогоо өлгүүрт өгөлгүй, хажуудаа тавиад буйдан сандалд суухыг үзвэл энд удахгүй бололтой.

Саша бүжгийнхээ хичээлийг зааж байв. түүнийг зочидтой зэрэгцэн ирэхэд Семён хуруугаараа дохиж дуудав. тэрээр бүжгийн хичээлээ түр зогсоогоод Семён Григорьевич руу очиход цаадах нь түүнийг хүүхнүүдтэй танилцуулав:

– Ульяна Захаровна, Мария Константиновна. Энэ бол Александр Павлович.

– Та чинь ийм хүн байсан юм уу. Ирэнгүүтээ л нэр цууд гарчихсан гэж Мария Константиновна өгүүлэв.

түүний өргөн шанаа, онин бор нүд нь буриадархуу шинжийг илтгэж, өөриймсөг янзтай байвч цайлган царайтай гэхээргүй аж.

Саша танхим руу зааж,

– Миний хамаг алдар энэ дээ гэв.

Ульяна Захаровна түүн рүү инээмсэглэн харах аж.

Хонгор шар үсээ сүлжиж шилэндээ титэмлэн тогтоосон, ногоон туяатай дүрлэгэр бор нүдэнд нь мишээл гэрэлтсэн, бие хаа тэгш чилгэр энэ сайхан хүүхний харцанд бас өөр нэг юм гялсхийж байх шиг, сониуч зан юм уу, чухам юуг Саша ойлгосонгүй.

Семён Григорьевич босч, худлаа хээгүйтэн,

– За тэгэхээр, Саша, та манай зочидтой жаахан буу хал, би шавь нартай чинь түр хичээллэе гэхэд Мария Константиновна бас босч,

– Үгүй шүү. Намайг захирал руу оруулаад аль гэснээ цагаа хараад, – Бидэнд хорин минут

байна. Бид дээшээ театр руу орох гэж явна, замдаа танай үүгээр орсон юм гэж Сашад учирлав.

Энэ мурилт түүнийг Ульяна Захаровнатай хоёулхныг нь үлдээх гэсэн зорилготой нь чухамдаа илэрхий байв. Хүүхэн инээмсэглэсэн хэвээр, дүрлэгэр нүдээ яльгүй сүүмийлгэн түүнийг харж, дэргэдэх буйдан сандлаа заагаад,

– Та суу л даа гэв. Саша,

– Баярлалаа гээд суув.

Хүүхэн сайхан сүрчиг ханхлуулан түүн рүү эргэж, сандлын тохойвчийг хөхөөрөө шүргэх шахам налан тохойлдов.

– Таныг Москвагийн хүн гэж би дууллаа.

– Тийм, би Москвагийнх, Арбатынх.

Хүүхэн дахиад нүдээ дүрлийлгэхэд, Сашад ойлгомжгүй бас нэг юм гологноод явчихав.

– Бид хөршүүд юм байна, манайх Грановскийн гудамжинд байдаг юм.

– Зөвлөлүүдийн Тавдугаар байшинд биш биз дээ?

Ээ чөтгөр чамайг! Ингэж ам алдана гэж байх уу. Энэ байшинг яаж мэддэгийг нь одоо шалгаагаад эхлэнэ, танил улсын нэр ус асуух юм болно. Тэгвэл хэнийг хэлэх вэ? Буудуулсан Будягиныг нэрлэх үү? Сонинд цухас гарсан ардын дайсны нэрсээс харах юм бол тэндхийн бүх хүнийг шоронгийн тав болгочихсон. Тэдний оронд энэ шинэ дээдчүүл орчихож.

– Таачихлаа. Тэнд таны танилууд бий юү? хэмээн хүүхэн түүн рүү улам ханарав.

– Энэ байшингийн зарим хүүхэд манай сургуульд сурдаг байсан юм: Петя Ворошилов, Иван Иванович Михайловын Вера, Тамара гэдэг хоёр охин. Энэ ч аль хэзээний, арваад жилийн өмнөх явдал, би бүр хуу мартаж орхиж.

Хүүхэн гараа түүний гар дээр тавихад, булбарай алга нь дулаахан аж. тэрээр өөриймсөг инээмсэглэн,

– Бид нар чинь арай нэг дор сурч байсан юм биш биз дээ? Та ямар сургуульд байсан бэ? гэв.

– Тээврийн дээд сургуульд.

– Тээврийн дээд ээ? Тэр чинь бүжигтэй ямар холбоотой байдаг билээ? гэж хүүхэн гайхшран асуув.

– Би гавихгүй инженер болж таараад, хөгжим, бүжиг рүү татагдчихсан юм. Тэгсэн нь ганц би ч биш.

мань хүн энэ ярианаас залхаад эхлэв. Тэгээд чилээгээ гаргах мэт мөрөө шилгээн гараа суллаж аваад сандлын түшлэгийг налав. Тэгтэл хүүхэн,

– Алив гараа өг л дөө гээд гарыг нь дахин атгаж, – Би таныг тийм амархан тавихгүй шүү. Би ч гэсэн бүжиглэж сурахыг хүсч байгаа юм бил үү. Та надад зааж өгөх үү? гэв.

– Бололгүй яахав, одоо ч болж байна.

– Одоо бол Мария бид хоёр театрт орно, тийм учраас дараа яая. Саша, таны зөв хэмээн тэрээр харилцан итгэж, таашаалтай байгаагаа цохох мэт түүний нэрийг онцолсхийн өгүүлэв.

– Таны зөв, олон жүжигчин одооных нь мэрэгжилд огт хавирахгүй боловсрол эзэмшсэн байдаг, тэгэхээр би бол таны хувьд ямар нэгэн тус болж чадах байх. Би, Александровын, Игорь Моисеевын энэ тэр гээд бүх чуулгын удирдлагыг мэднэ. Мэдээж, маш том өрсөлдөөнт шалгалтаар тийшээ орно, тэглээ ч гэсэн манай нөхөд танд туслахыг хичээнэ. Өө, Мария ирж явна, хоёулаа энэ яриагаа үргэлжлүүлнэ ээ. Та хичээлээ хэзээ дуусгадаг юм бол?

– Арван цагт.

– Жүжиг арав арван тавд дуусна. Биднийг хүлээж байгаарай, Машагийн д жаахан сууцгаая, ам халцгаая.

Тэгээд Сашагийн хариуг хүлээлгүй босоход, мань хүн түүнд пальтог нь авч өгөв.

– Цаад хүүхэн чинь чамд ухаан тавьчихлаа гэж Глеб явуулав.

– Харин тэгэх ч шиг.

– Тэнд ажил их бий.

– Дэндүү түшмэл зантай юм.

– Гэхдээ туршлагатай, энэ аргаараа зиндаа олсон хүүхэн.

– Хүлээж байгаарай гэсэн. Түй, чөтгөр гэж! Нэг л дургүй хүрээд байна. Тийшээ очихгүй ээ, яршиг.

– Хүүш, ялдам аа, чи чинь солиороо юу? Цаадуул чинь бүх юмаа ярьчихсан, хамаг төлөвлөгөөгөө боловсруулчихсан байгаа, зүгээр л энд ирсэн гэж бодоо юу? Тэр хүүхэн чинь аль өчигдөр чамд нүд алдчихсан юм. Уулзахаар чинь ууна, иднэ, бүх юмаа бэлдчихсэн хэрэг. Чамайг зочилж ирээч гэж байхад чи татгалзсан болох нь байна. Ёстой тэгж болохгүй. Тэгэх юм бол Мария Константиновна чамайг ёстой араандаа зуучихна. Чи түүнд их өртэйгөө битгий март. Нэг хоёрхон сар болоод энд байх зөвшөөрөл чинь дуусна, тэр үед чи: “Мария Константиновна минь аварч үзээрэй” гээд дахиад л түүн рүү очно. Тэгэхэд чинь: “Уучлаарай, Александр Павлович, та биднийг тоодоггүй хүн, тийм учраас дахиж бидэнд найдахын хэрэггүй” гэж хэлнэ шүү дээ. Тэгж хэлэх нь ч зөв байх болно.

Саша тээнэгэлзээд байв. Мэдээж сэтгэл гижигдэм зүйл. Гэхдээ нэг юм чангаагаад байна.

Намын ТХ-ны хүн, мань хүн түүнтэй юу ярих билээ? Ингэх хэрэг өөрт нь юу байна?

– Ёстой гоё согоо! Тэнэг хүн л түүнээс татгалзана. Онгон сахиус, охин тэнгэр! Эндхийнх байсан бол би өөрөө эргүүлэх сэн. Гэтэл тэр Москвагийнх, чухал хүн, тэгээд чи: пээ, миний тухай юу гэж бодох бол, ашиг хонжоо харж байна, ахих дэвших юм бодож байна гэж хэлнэ, би бол Растиньяк биш, Потёмкин биш, Орлов гүн биш, эрхэм ёс суртахуунтай хүн... гээд гэдэн чинь хөдөлчихөж хэмээн Глеб үглэв.

– Үгүй ер, Растиньяктаа хүрчихдэг байна гээд Саша мушилзав.

– Ялдам минь! Чи бол юуных нь Растиньяк, Потёмкин байх вэ дээ. Тэр хүүхэн чиний муу явдлыг халах юм уу? Чиний муу явдлыг хэн ч халж чадахгүй, ер нь ч чи тэр тухай ганц үг ч ганхийхийн хэрэг байхгүй. Нэг юм болох юм бол яахав дээ, хажууд тийм хүүхэн байхад аятайхан нийллэгнээр юу эс болохыг тэр гэхэв.

Театраас холгүй, хөл хөдөлгөөнгүй хөндлөн гудамны багашаархан нэг давхар байшин. Гудааных нь шал хивсэнцэртэй, нэг ханаараа урт өлгүүртэй, нөгөө ханандаа тольтой аж. Ульяна үстэй дээлээ өлгөөд толины хажуугийн сандал дээр лагхийн суухад Мария улавч авч өгөв. Ульяна босч, ямар нэг юм тээр болоод байгаа юм шиг сунналаа.

– Илүү хувцаснаасаа салах минь. Танай хоолны өрөөнд дулаахан уу?

– Галлачихсан байгаа. Би чамд халаад өгье.

Ульяна Саша руу харав.

– Би халаад өмсвөл та дургүйцэхгүй биз, Саша?

– Хаанаас даа!

Хоолны өрөө рүү орцгоотол Мария,

– Энд суузгаж байгаарай, бид хоёр одоо хүрээд ирнэ. Явья Ульяша гээд

хоёр хүүхэн гарав.

Саша өрөөг эргүүлдэн харлаа. Дүүжинтэй ханын цаг, эвтэйхэн өлгөлсөн жижиг зурагнууд, төгөлдөр хуур, эрчлээстэй бүдүүн хөлтэй дугуй ширээн дээр угас байна. Улаан модон тавилга, Саша ийм эдний учрыг сайн мэдэхгүй, гэхдээ хуучны үнэтэй эд гэдгийг ойлгоно. Орос маягаар тоногдсон голланд зуух. Дулаахан бөгөөд тохилог аж.

Гэрийн хувцсаа өмссөн Мария эргэж ирээд, ширээнийхээ бүтээлгийг сольж, гурван хүний хоолны хэрэгсэл, хундага сэлтийг тавилав.

– За, Сашенька энд ямар байна, таалагдаж байна уу?

– Тансаг байна, бүр минийхээс ч ванлий юм гээч.

Хүүхэн эгдүүцэн толгой сэгсрэв.

– Сашенька, би тэр байрыг чинь энд бүртгэл хэрэгтэй хүнд хадгалж байдаг юм. Та тэнд амьдрахгүй байгаа шүү дээ.

– Мэдээж.

– Ийшээ ирэнгүүтээ над дээр ирсэн бол хотын төвд төвхнүүлчих л байсан. Гэтэл та хугацаа хэтрүүлсэн учраас тийш нь явуулахаас өөр аргагүй болсон.

– Харин тийм ээ, би танд маш их баярласан шүү. Би гоомой хандсан байна лээ, та л аминд орсон гэж Саша үнэн санаанаасаа хэлэв.

Ульяна халаад өмсчихсөн, гэзгээ задлан хоёр мөрөн дээгүүрээ сэвсэлзүүлсээр орж ирэв. Бараг задгай халаадных нь цаанаас чийтэй чилгэр цагаан хөл, булбарай өвдөг илхэн харагдана. Бүх юм илэн далангүй буй учир түүний ногоон туяатай бор нүдэнд юу гологноод байсан нь ойлгомжтой болов: төв хорооны ажил хэрэгч хүүхэн худлаа маяглаад байхгүй, оронд ороод л явчихна, тэгсэн цагт чаддаг л юм бол чадна биз гэж байсан байх нь. ТХ-ндөө бол өндөр ёс суртахуунтай дүрийг эсгэж байх ёстой болдог, харин энд, дарга нар болоод доод албаныхнаасаа хол газар өөрийн хувийг хүртэж болно. Мария мань эрийн хэн гэдгийг түүнд хэлээгүй нь мэдээж.

Мария ширээн дээр зууштай таваг тавилах зуур,

– За, манай эрхэм шонхорууд, аягүй бол өлсчихсөн байлгүй. Юу уух болж байна? Саша, танд цагаан архи байх, Ульяша чи юу уух вэ? гэв.

– Надад ч бас жаахан архи хийчих.

Мария хундагануудыг дүүргээд,

– За, залуус минь, уулзсаны төлөө ууцгаая гэв.

Ульяна бас хундагаа өргөснөө харц нь гэнэт буурьтай болж,

– Манай эх орны нийслэл, Москвагийн төлөө ууцгаая. Саша бид хоёр нэг нутгийнх, бараг хөршүүд юм чинь гэв.

Хаяагаа манаж байна. Сашатай унтчих юм бол хэн ч ухаж төнхөж чадахгүй. Уухын тухайд гэвэл, найз хүүхнийдээ эх орныхоо нийслэлийн төлөө ганц хундага татсан л байгаа биз.

Ууцгаалаа. Зуушаар даруулцгаалаа. Хар, улаан түрс, хандгайн мах, гахайн утсан мах гээд ийм зуушийг Саша ойр найр хараагүй билээ. Сайхан аж төрөх дуртай, сурцгаачихаж.

Ульяна Сашад тавгаа өгч,

– Надад юм юмнаас жаахан хийгээд аль даа гэв.

Мария дарсан мөөг, хэмх, улаан лоольтой тавгийг дөхүүлэв.

– Манай давсалсан идээг амсацгаа.

Ульяна амсаж үзээд,

– Ямар сайхан юм бэ, танай Петровна дараа юу? гэв.

– Тийм.

– Гэрийн зууш л хамгийн сайхан. Даанч ийм юм хийж байх зав олдохгүй юм.

Хүүхэн тавгаа өвдөг дээрээ тавьсан нь идэхэд нэг их эвтэйхэн биш ч гэсэн зарим юмаа ил суухад зүгээр ажээ.

– Би та хоёрыг бас баншаар дайлна, манай Уфагийн баншаар.

Ульяна цагаа харснаа,

– Арван нэг өнгөрч байна. Зочид буудал руу утасдах хэрэгтэй гэв.

Босч утас руу очоод зочид буудал руу залгуулав.

– Большакова ярьж байна. Би найз бүсгүйдээ саатчихлаа, одоо машин дуудахад оройтчихож, эвгүй байна. Би эндээ хононо, та утас бичээд ав.

– Яах гэж утас өгч байгаа юм бэ? Шөнө төвөг удаад салахгүй гэж Мария өгүүлэв.

– Хэн ч утасдахгүй, би шөнийн цагаар хэнд ч хэрэггүй. Харин Сашенька сэжиглэхгүй бол хэрэг болж магад. Ямар вэ, Саша, над шиг амьтанд дуртай юу?

– Над шиг гэж ямар?

– Ичгүүргүй, эх захгүй шар толгойтнуудад.

За ингээд өөрийнх нь бодож байсныг хүүхэн өөрөө яг хэлчихлээ гэж бодоод Саша инээд алдан,

– Тийм хүүхэнд дургүй хүн гэж байх уу? гэв.

Ульяна түрүүчийнхээ яриаг үргэлжлүүлж,

– Намайг хаа хоносныг маргааш сонирхоод эхэлбэл хэрэг болно гэж утас өгч байгаа юм. Төвөөс яваа нөхдийг энд чинь дөрвөн нүдээр харуулдаад, хүн болгон унаа явуулах гэж оролдох юм гэв.

Мария босов.

– Би банш аваад ирье, харин эзгүйд битгий зүггүйтээд байгаарай.

Аргагүй л туршлагатай зууч...

Ульяна Саша руу ханаран, том ногоовор нүдээрээ тулган харснаа гэнэт ийн өгүүлэв:

– Хоногт арван зургаан цаг зүтгэж, хаанаас тэнгэр ниргэх бол гэж хором тутам анаж явна. Хааяа биеийн чилээ гаргаж болно биз дээ? Сайн хүнтэй! Чи юу гэж бодож байна?

мань хүн юу гэж хариулах ухаанаа олохгүй, тэгэлгүй яахав гэсэн мэт дэмий л дал мөрөө хавчив.

Ульяна түүнийг ширтсэн чигээрээ,

– Чи бол журамтай, сайн хүн биз дээ?

Саша хариуд нь хий жуумалзан бас л дал мөрөө хавчив.

– За ингээд ойлголцлоо, алив наашаа, үнсэлдье гээд Ульяна түүн рүү зүтгэв.

– Мария ороод ирнэ шүү дээ.

– Зүгээр, зүгээр, Машка манай хүн.

Тэгтэл ч,

– За тэр, урьдчилж анхааруулсан шүү дээ. Ганц минут тэсч чаддаггүй амьтад гэх Машагийн дуу гарлаа.

тэрээр банштай том пял ширээн дээр тавиад хүн бүрт тавгалж,

– Хэн нь цөцгий, хэн нь цуу, хэн нь чинжүү авна дураараа болцгоо, энэ бол үхэр, гахайн махан дээр хонины мах жаахан нэмсэн жинхэнэ банш шүү гэв.

– Ийм баншны өмнө юм балгахад гэмгүй гэж Саша санал болгов.

мань хүн юм татмаар байж. Ульяна чин сэтгэлээсээ ярьж байна уу, эс бол энэ нь өөрийгөө зөвтгөх ердийн арга уу? Ямар ч ялгаа байх вэ дээ! мань хүн өөрөө ч гэсэн хүүхний бодож байгаа хүн биш юм чинь. Тийм учраас хайнаа. Хүүхэн зугаацахыг хүсч байна, өөрөө ч бас тэгэхээс буцах юм алга. Тэгэхээр юм балгах хэрэгтэй.

– Зүйтэй, өөртөө ахиухан шиг, бидэнд арай бага хийчих. Алив, Ульяна, тайвшруулах эмний оронд хэмээн Мария саналыг нь дэмжлээ.

Ульяна бусдын адил татчихлаа... Нэг банш идсэнээ Сашаг хараад гарыг нь барив.

– Ульяна, хүн юм идүүлээч! хэмээн Мария зандрав.

– Идэж л байг л дээ, хэн саад болоод байгаа юм?

Мария амаа арчин босоод,

– За, багачуул минь, та нар бол эрх чөлөөт улс, харин би бол есөн цагт албан дээрээ байх ёстой. Тийм учраас сайхан нойрсоцгоогоорой гэснээ утасны ширээ рүү зааж, – Ульяша, түлхүүр тэнд байгаа, өдөр би чамаас авчихна. Манай Петровна аравт ирнэ гэж мэдээрэй... гээд тэр хоёрыг үнсэхдээ, Сашагийн хацрыг илэнгээ – Дажгүй эр шүү! гэв.

Хөшигний завсраар зурвас гэрэл зурайж, хоолны өрөөнд сав суулганы чимээ гарах үед Саша сэрэв. Ульяна хажууд нь хөдлөх аядаад, дэр рүүгээ амаа наан,

– Хэвтээнэ, Машка сав суулгаа эмхэлж байна гэж битүү шивнэв.

мань хүн нүдээ анитал сав суулганы чимээ тэгсхийгээд намжиж, удалгүй үүдний хаалга торхийв.

Ульяна орноосоо босч,

– Машка явчихлаа. Би одоо ирнэ ээ гэв.

Буцаж ирээд, хөнжилд орж Сашад наалдав.

– Тий-тий, хүйтэн байна гэснээ ширээ рүү гараа явуулан цагаа авав. – Хүүш, бараг ес болчихож гэнгүүт цагаа буцааж тавиад Сашаг тэвэрч, – Чамтай ингээд үүрд хэвгчих юм сан. Даанч ажил дээр харагдалгүй горьгүй, алив, хонгор минь, босцгооё, хувцасла хэмээн хөнжлийг нь хуу татав.

Саша босч хувцсаа өмсөв.

– Би чамайг явуулчихья, дараа нь хувцаслаад өөрөө явна, би чинь үсээ янзлах гэж хагас цаг болно. Машкагийн үйлчлэгч ирээд намайг байгааг мэдэхэд гэм байхгүй, харин хоёулаа харагдаж болохгүй, чи ойлгож байгаа. Москвад хэзээ очих юм бэ, хэлэхгүй юү? Би чинь өнөөдөр явчихна шүү дээ.

– Өө тийм үү? гэж Саша гайхшрав.

– Тийм шүү, хонгор минь, өнөөдөр шөнийн галт тэргээр. Тэгээд хэзээ Москвад очих юм бэ?

– Би Саратов явна гээд Семён Григорьевичид амалчихсан.

– Их юм болж дээ, Семён Григорьевич чинь ердөө л дэд хашаачны ахлах туслах. Чи Москвад байртай юу?

– Ээж маань Москвад суудаг юм.

– Чи ямар дурандаа ингэж элдэв хотоор тэнүүчилж явдаг юм бэ? Би Москвад бүх юмыг чинь зохицуулаад өгнө шүү.

мань хүн орон дээр суузнав.

– Чи чинь юуг ч чаддаг хүн юм уу? Хаана ажилладаг болж байна?

Хүүхэн түүн рүү итгэл муутай харав.

– Чи мэдэхгүй байгаа юм уу?

– Би яаж мэдэх сэн билээ?

Хүүхэн жаахан түгдэрснээ,

– Урлагийн хороонд ажилтай, Москва руу очихын цагт миний утсыг Мариягаас аваарай. Миний утсыг өгөөрэй гээд би түүнд хэлчихнэ гэв.

– Би чамд утасдана аа гэж Саша хэлэв. Гэхдээ хэзээ ч утасдахгүйгээ мэдэж байгаа болохоор, – Гэхдээ миний насан дээр зиндаа эхлэнэ гэдэг оройтсон хэрэг. Гоцлол бүжигчин болж чадахгүй, нийтийн дунд явах хүсэл алга. Гэхдээ чамаас нэг гуйх юм байна. Миний хамтран тоглогчийг хараа биз дээ?

– Тэр шар толгойт уу?

– Тийм. Тэр чинь театрын зураач, Ленинградд Акимовын удирдлагад ажиллаж байгаад дараа нь Калининд Залуу үзэгчдийн театрт байсан хүн. Уран сайхны удирдагчтайгаа хэл амаа ололцоогүйн учир тэндээсээ явчихсан юм. Овог нь Дубинин, Глеб Васильевич гэдэг юм.

– Тэрний чинь бүх юм ёсоороо байгаа юу?

– Ямар утгаар тэр билээ?

– Ойлгохгүй байж гэнэ... Ямархан цаг үе билээ, ойлгож байна уу?

Саша дал мөрөө хавчин жуумалзав.

– Нам бус, шүүгдэж байгаагүй хүн.

– За мэдлээ гээд хүүхэн цагаа дахин харснаа халаадаа яаран өмсөж, – За яахав, цаадахдаа, өчигдөр Мария Константиновнаг дөхүүлж өгөх зуур чиний тухай хэлсэн, тэгсэн чинь чамайг уулзаарай гэсэн гэх маягийн юм хэлчих. Машкагаар дамжуулаад тэрүүнд чинь туслая. Алив, би чамайг гадагш нь гаргаж өгье гэв.

Үүдний гудаанд Саша пальто, малгайгаа өмсөхийг харан, хана налан зогсож байснаа,

– За тохирсон ёсоор шүү. Гудамжаар эргэж харах энэ тэр гэлгүй тайван яваарай гэв.

Тэрээр яагаад Ленад Уфа гэж хэлсэн билээ, яагаад Сашаг дурссан билээ? Саша Софья Александровнагай утсаар ярихдаа өөрийнх нь мэндийг асуудаг гэж байгаа. Варя үүнд дотроо талархалтай байвч, мэнд ус асуусан гэж эс итгэнэ. Софья Александровна ёс бодож, эсвэл зүгээр тайтгаруулах гэсэндээ л тэгж хэлж байгаа байх. Саша өөрийг нь амьдрал, сэтгэлээсээ хөсөр таягдан хаясан, Костятой болсон явдлыг нь уучилж чадахгүй байгаа гэж бодно.

Варя заримдаа шал өөр шалтгаан байгаа гэж өөртөө итгүүлэх гэж бас оролдоно. Саша улс орноор тэнүүчилж яваа, амь насанд нь өчнөөн аюул занал тохиож байгаа, тэгэхээр өөрийг нь бас аюулд өртүүлэхийг хүсэхгүй байгаа. Гэтэл бөглүү хөдөө нутагт амар жимэр аж төрөх гэсэн өөрийнх нь мөрөөдөл ч аль хэдийн хийсч арилсан, одоо хэнд ч амар жимэр амьдрал гэж байхгүй. Гагцхүү Саша өөрт нь хайртай гэдгийг л мэдвэл бол оо. Бас өөрийнх нь хайртай гэдгийг Саша мэдэж байх хэрэгтэй. Заримдаа утсаар ярьж, захиа бичиж, амралтаараа ганц хоёр хоног ч болохноо оччихоод байвал л болох нь тэр. Тэгвэл тэр хоёрт дундын гэр, хүүхэд байхгүй, айл өрх болоогүй нь падгүй хэрэг. Ингэж бодоход гол харлам байгаа нь мэдээж, тэглээ ч гэсэн үгүйдээн тийм л байг. Гол нь хоёр биендээ хэрэгтэй гэдгээ мэдэж байх сан.

Гэтэл мань хүүхэн нэг удаа шар толгойтой, хариугүй нялзрай амьтныг зүүдэлсэн, тэр нь өөрийнх нь хүү ч юм шиг, үстэй даавуунд өлгийдөн тэврээд, үнсэлж бас уйлж, өрөөн дундуураа холхиж байсан. Яагаад шар толгойтой байна гэж хүн болгон гайхширч асан. Саша хар үстэй, өөрөө бас тийм, гэтэл хүү нь шар үстэй байдаг!

Тэгээд сэрчихсэнээ зүүдэнд дахиж орж магад гэж горьдон босмооргүй байсан, Саша тэр хоёрын дундаас гарсан хүүхдийг үгүйдээн зүүдэндээ ч болохноо эрхлүүлэхгүй юу!

Тэгсэн чинь, хачин хэрэг шүү, энэ зүүд нь түүнийг хэрсүүлжүүлжээ. Уул нь, нөгөө ойлголцоогүй явдал шийдэгдэнэ, Саша заавал захиа бичнэ гэж санагдаад, амралтаараа нагацындаа хүртэл очоогүй билээ. Эзгүй хойгуур нь Сашагаас захиа ирээд, өөртэй нь уулзая гэсэн байвал яах вэ, дараа нь толгойгоо шаах хэрэг болно гэхчилэн бодож асан. Тэгтэл ажил руугаа метрогоор явж байхдаа харанхуй хонгил руу гөлөрч яваад, үл ойлголцоон шийдэгдэхгүй, Саша тэр хоёр уулзахгүй гэдгийг ойлгожээ. Саша суллагдсанаасаа хойшхи бүтэн хагас жилд ганц мөр ч бичээгүй, ганцхан удаа утасдсан, гэхдээ Софья Александровнагийн шахалтаар тэгсэн гэдэгт өөрөө эргэлзэхгүй байгаа билээ. мань хүн амьдралаа холбохоос айж байгаа бол: “Надад маргааш юу тохиохыг би мэдэхгүй, чиний амьдралыг, чиний эрх чөлөөг эрсдэлд оруулах эрх надад байхгүй, намайг март” гээд биччихэж болох байсан. Бичээгүй. Тэгэхээр юмны учир Костя л болж байна. мань хүн тэр тухай бичихийг хүсэхгүй байна. Харилцааг нэг мөсөн тас цохьсон байна, тэгэхээр үүнтэй эвлэрэх хэрэгтэй. Тэр бол амьдралаараа хохирсон, хөөгдөж туугдаж яваа хүн, өөрт нь итгэж байсан, гэтэл Костягийн тухай сонсоод мэл гайхсан, доромжлол хүлээсэн. Тэр бол шийдэмгий хүн, эр хүн, тэгээд өөрийг нь хөсөр таягдан хаясан. түүний түгшүүрт амьдралд өөрийг нь байлгах зай одоо байхгүй, ердөө л ор тас мартсан байгаа. Гэхдээ өөрөө бол хэзээ ч түүнийг мартажгүй. түүнийг Казанийн буудал дээр хоёр хуягийн дунд нуруундаа үүргэвчтэй, чемодан барьчихсан явж байсан өдрийг яаж мартаж сан билээ. Тэгэхэд өөрийнх нь харж буйг мэдрэхдээ эргэж харахад нь царай нь хувхай цагаан, цыган шиг хар хуузтай байсныг харсан.

Тэр бол өөрөө хэнийг ч, өөрийг нь ч хараагүй. Тэр нэг өдөр өөрийнх нь амьдралыг орвонгоор нь эргүүлж, энэ хайр найргүй, шудрага бус хорвоогийн айдас хүйдсийг анх удаа мэдрүүлсэн. Энэ өдрийг тэр хэзээ ч мартахгүй, Сашаг хэзээ ч мартахгүй, байнга санаж, хайрлаж явах болно, түүнд үнэнч байх болно, Софья Александровнаг хэзээ ч орхихгүй. Варя урьдын адил өдөр болгон авгай руу утасдаж, харих замдаа заримдаа гэрээр нь ордог боловч одоо бүх сул цагаа Лена Будягиныд өнгөрөөх нэгэн шинэ ажилтай болоод байгаа билээ.

Ленаг ажилд оруулах гэсэн Игорь Владимировичийн оролдлого бүтэхгүй байв. Нөлөө бүхий танилууд нь бүсгүйн овгийг дуулмагц тус хүргэхээс шууд татгалзаж, хэн нэг нь боловсон хүчний хэлтэс хүртэл хөөцөлдлөө гэхэд тэд нар нь татгалзана.

Лена дүүгээ хүүхэд асрах газар өгчээ.

– Бид хоёрын яаж салсныг чи харсан бол ч. Владлен намайг үнсээ ч үгүй, зүгээр хөндлөнгийн хүн шиг толгой дохих төдий болсон хэмээн Лена өөрт нь халаглан ярьж, – Чухам аль асрах газар очсоныг сарын дараа мэдэж болно гэж хэлсэн. Тэр сар нь надад заяах эсэхийг бүү мэд. Манай энд муу л юм дуулдаад байна.

– Юу гээч вэ?

– Эндээс цөлөгдсөн бүх хүнийг шинэ очсон газар нь баривчлаад хорих руу явуулчихсан гэнэ лээ. Ухаантай бодож олно шүү. “Ардын дайсны” авгайг энд баривчлах юм бол байранд нь хамаатан садан нь үлдэнэ. Харин бүх гэр бүлээр нь, жишээ нь, Астрахань руу цөлчихвөл Москвад байр нь сулрана. Удахгүй маний ээлж ирнэ, ердөө арван хоёрхон айл үлдээд байгаа. Хэдхэн хоногийн хугацаа байгаа. Бодвол, намайг хорих руу явуулаад, Ваняг хүүхэд асрах газар өгчих байх.

– Чи тэд нарт хүүгээ үнэхээр өгөх юм гэж үү?

– Би юу хийж чадах сан билээ? Аравдугаар давхарт суудаг сан бол хүүтэйгээ цонхоор үсэрчихсэн. Гэтэл нэг давхраас хаашаа үсрэх вэ дээ?

– Балай юм яриад л.

– Балайг нь мэдэж байна. Гэхдээ аливаа бусад яриа ямар ч ашиг байхгүй.

– Яагаад яваад өгч болохгүй гэж?

– Хаашаа?

– Би чамд Мичуринск гэж хэлж байсан шүү дээ.

– Варенька, тэр эгч чинь Ваня бид хоёрыг тэжээх юм уу? Ажил хайх хэрэг болно, тэгэхээр чинь эцэг, эх чинь хэн бэ гээд л биеийн байцаалт бөглөх хэрэгтэй болно. Тэгээд л дор нь бариад авна. Бөглүү нутагт. Энд бол үгүйдээн нийслэлд баригдах юм. Чи надтай санал нийлэхгүй байна аа даа?

– Нийлэхгүй байна. Та нар яахаараа шорон, цөллөгт ийм дуулгавартай явж байдаг юм бэ? Бүр өөрсдийнхөө үр хүүхдийг хүртэл аврахгүй юм! Хорих газар, шорон, цөллөгт сая сая хүн байж байна. Бүгдээрээ гэнэт зугтчих юм бол хэн тэднийг барих юм бэ? Барихын тулд зуун ДЯАК байсан ч хүрэлцэхгүй.

Лена сандал дээр лагхийн суулаа.

– Бүх юм оройтсон, хожигдсон, хуу няцлуулсан, бид юу хийхээ мэдэхгүй байна. Үгүйдээн Ванягаа аврах юм сан, гэтэл яаж аврах вэ?

– түүнийг найдвартай хүмүүсийн гарт өгчихөөд, өөрөө алга болчих хэрэгтэй.

– Тэр найдвартай хүмүүс чинь хаана байна, чи мэдэж байгаа юм уу?

– Чиний Мотовилихд бас Бакуд байгаа хамаатнууд чинь хүүхдийг чинь үнэхээр авахгүй гэж үү?

– Би олдог юмаа гэхэд тэд авахгүй. Заяа нь авахгүй.

– Тэгвэл одоохондоо би авч байя, тэгэх үү? Чи тэднээс бултаад, найдвартай төвхнөж чадвал би хүүг чинь буцаагаад өгнө, чадахгүй бол би өсгөө.

– Варенька минь баярлалаа, гэхдээ энэ бол бодитой биш. Чи ажиллах ёстой, суралцах ёстой, Ваня хэнтэйгээ байх болж байна?

– Надад Софья Александровна туслана, Сашагийн ээж.

– Тэр ч бас ажиллаж байгаа. Үгүй ээ, би тэгж чамд ч, тэр авгайд ч хэзээ ч дараа болохгүй.

– Тэгвэл танай Машад чинь тосгонд хамаатан бий юу?

– Тэрний эцэг эхийг нудраганчууд гээд цөлчихсөн, мань хүүхэн жаахан байхдаа хөдөөнөөс зугтаад манайд ирсэн царай нь тэр.

– Хүүхдээ аваад ерөөсөө өнөөдөр Мичуринск яв. Би та нартай цуг яваад эгч авгайндаа төвхнүүлж өгье.

– Би тэгж азаа үзэж чадахгүй. Танихгүй хотод хийх ажилгүй, идэх хоолгүй, нялх хүүхэдтэй, нэмэрт нь аль ч агшинд барьж аваад шоронд хийчих аюул өвөрлөж явснаас хорих, цөллөг энэ тэр рүү явсан нь дээр.

Варя урам хугаран гарч оджээ.

Цөмөөрөө хулчгар амьтад, цаг нь хэзээ ирэхийг үг дуугүй хүлээцгээнэ. Даанч тэр муу хүүг нь өрөвдөх юм, хөөрхөн амьтан, “ардын дайсны” хүүхдэд зориулсан нэг муу газар хаячихна. Энэ нялх амьтдаас хэд нь амьд мэнд гардаг юм бол, амьд мэнд гарлаа гэхэд хаанахын, хэн болохоо ч мэдэхгүй дээ.

Варя харих замдаа шуудангаар ортол Нинагаас захиа ирсэн байв. Нина өөрөө авах хаягаар долоо хоног болгон алдахгүй бичдэг юм. Бүр анхныхаа хэдэн захидлаар л: “Бүх юм дажгүй, ахлах ангид түүх зааж байна, энд багш хүрэлцдэггүй юм байна. Максим бид хоёр бүртгүүлсэн, би одоо Костина болсон” гэж мэдээлсэн.

Дараачийн захидлууддаа: сонин юм алга, бүх юм ёсоор байна гэхээс өөр гойдын зүйл бичихээ больсон, харин өнөөдрийн захианд түгшүүр мэдэгдэж байв: “Манай эндхийн хэрэг явдлын талаар чи, мэдээж, мэдэж байгаа. Бүх юм гайгүй байх болов уу гэж найдаж байна”.

Ямар хэрэг явдлын тухай ярина вэ?! Наймдугаар сарын нэгнээр өдөрлөсөн захиа байна, өнөөдөр арван таван. Захиа хоёр долоо хоног явж ирдэг. Наймдугаар сарын эхээр юу болсон байх вэ? Варя зарчмын үүднээс сонин уншихгүй, радиогоор бол зөвхөн цаг агаарын мэдээ л сонсоно, засгийнхны худал үгийг сонсох ч дургүй, унших ч дургүй. Алс Дорнодод япончуудтай мөргөлдөөн болсон маягийн юм чихний нүхээр орсон тал бий. Гэхдээ “японы самурайнуудтай” манайхан байнга үзэлцдэг шүү дээ. Варя маргааш нь ажил дээрээ очоод ямар учиртайг мэдэж авчээ: долдугаар сарын 29-нөөс наймдугаар сарын 11-нд Хасан нуурын орчимд зөвлөлт, японы цэргийн хооронд ширүүн тулалдаан болсон, япончуудыг үлдэн хөөсөн, эвийн хэлэлцээрт гарын үсэг зурсан ажээ. Нина юун тухай бичиж байсан нь ойлгомжтой. Макс байлдааны ажиллагаанд оролцсон учир Нина нөхрийнхөө төлөө санаа зовж байжээ. Тэр нь амьд мэнд байдаг байгаа даа?

түүний ухамсарт дайн анх удаа бодит зүйл болж орох нь энэ. Варя дэлхийн дайны тухай ч, иргэний дайны тухай ч уншиж байсан, сургуульд заалгаж байсан, гэхдээ энэ бол аль дивангарын, алсад болсон явдал, гэтэл энэ удаа Максыг дайнд алчихаж мэдэх байсан байна. Мэдээж цэргийн хүний үүрэг бол байлдах, гэхдээ дайны хэрэг юу байна? Гэтэл одоо Герман, Японы зүгээс “дайны аюул” нөмрөн ирж байгаа тухай чих дөжиртөл ярьж байна. Гэтэл нөгөө япончууд нь довтолж, манай нутаг руу довтолж. Хасан нуур манай нутаг дээр байгаа. Варя “Правда” худалдаж аваад, Алс Дорнодын тухай мэдээ олж үзэв. Орой нь радиогоо залгаж, сүүлийн үеийн мэдээг эхнээс нь дуустал сонсов.

Хэрэв Макст ямар нэг юм тохиосон бол Нина хэлэлгүй яахав. Эсвэл мэдээлэхийг хориглодог юм болов уу? Манайд чинь бүх юмыг чадна. Хичнээн япон алагдсан, шархадсан тухай сонинд бичээд байгаа хэрнээ манайхан хэдийгээ алдсан тухай бичихгүй, нуугаад байна.

Яадаг хэрэг вэ? Цахилгаан явуулдаг юм бил үү? Нина Сергеевна Костинад: “Эрүүл мэндээ мэдэгд” гээд. Хэний эрүүл мэндийн тухай лавлаж байгааг Нина ойлгоно. Гэтэл тэдэнд хор хүргэчихвэл яана? Бүх юмыг нууцалчихсан, бүх юм нууц... “Яагаад танай хамаатан санаа зовоод байна, нөхөр Костин байлдаанд оролцсоныг тэр чинь мэдэж байгаа юм уу? Хаанаас мэдсэн хэрэг вэ? Та түүнд мэдэгдсэн юм уу? Яах гэж тэр вэ?” гээд шалгаацгаана. Новшийн орон! Алхам болгон, хөдөлгөөн болгон аюул дагуулна.

Хажуугийн орцонд суудаг Максын хамаатныхаар, юу байна, яаж байна, дайн болсон шүү дээ гэх маягаар ордог ч юм бил үү? Гэвч өөрөө Макстай цуг сурч байгаагүй, найзалж байгаагүй, гэр орноор нь ерөөсөө орж гарч байгаагүй, хамаатнуудтай нь бараг танил биш, тэгсэн чинь сандарсан хүн гэнэтхэн орж явчих нь. Үгүй ээ, тэгж болохгүй.

Варя ийн санаа зовж байгаагаар Софья Александровнад хэлтэл, Максимын эхээс сайн лавлаж өгөхөөр амлав. Софья Александровна хоёр хоногийн дараа утасдаад, Костины гэр бүлийнхнээр ямар ч муу мэдээ алга гэжээ. Варя үүнийг сонсоод тайвширсангүй. Төрсөн эхээс нь ч нуухаас сийхгүй юм чинь. За яахав! Дахин нэг долоо хоног хүлээгээд дараа нь цахилгаан явуулна.

Цахилгаан явуулах шаардлага гарсангүй. Хэд хоногийн дараа Софья Александровна дахиад ажил руу нь утасдлаа:

– Варенька, өнөөдрийн сониныг хараарай. Тэнд Максимын тухай байна.

– Юу, муу юм уу?

– Үгүй ээ, харин ч сайн юм.

Варя сонин хайж олов. Хасан нуурын тулалдаанд оролцогсдыг, хэдэн мянган хүнийг одон, медалиар шагнасан аж. Гэхдээ сонинд зөвхөн Зөвлөлт Холбоот Улсын баатруудын нэрийг дурджээ. Тэдний дотор батальоны дарга Максим Иванович Костин орсон байв.

Макс – Зөвлөлт Холбоот Улсын баатар! Энэ улсын хамгийн дээд цол. Одоо Нина түүний ард чулуун хэрэмний ард байгаатай адил гэсэн үг. Одоо түүнд халдаж зүрхлэхгүй.

Тэгээд Варя, Нина Макс хоёр бяцхан Ваня Будягиныг дэргэдээ авч, бүр үрчилж аваад овгоо өгч болох юм гэж гэнэт боджээ. Тэднийх хүүхэдгүй, бодвол, мөнгө нь хүрэлцээтэй байх, тэнд, цэргийн хотхонд ясли, цэцэрлэг гарцаагүй байгаа. Хүүхэд хаанаас аваав? Дүү Варягийн хүүхэд л гэгчихнэ биз, хэнээс олсныг бүү мэд, тэр садар хүүхний хажууд энэ хүүхэд балралтай нь биш, жинхэнэ зөвлөлтийн иргэн, социалист эх орныхоо мятрашгүй хамгаалагчийг хүмүүжүүлэх санаатай байна. Заяагүй новш чинь хүрч ирээд, энд хүүхдээ хаячихаад, энэ: “М.Н. болон Н. С. Костиныхонд Иван хүүгээ үрчлүүлэхийг зөвшөөрч байна. В. Иванова” гэсэн бичиг үлдээчихэж гээд л гүйцээ. Баримт бичгийн ь бүрдүүлээд өгнө, ямар Москва биш, нэмэрт нь зүгээр хэн нэгэн биш, Зөвлөлт Холбоот Улсын баатар!

Лена зөвшөөрөх болов уу, яах бол? Эх хүн юуны өмнө хүүхдээ аврах ёстой. Нина зөвшөөрөх болов уу, яах бол? Тэр дотнын найздаа туслахгүй байж яаж чадах билээ? Нам нь түүний хамаг хүнлэг чанарыг нядаачихсан гэж үү дээ? Харин Макс бол Нинагийн юу гэж хэлснээр л болно, сайхан сэтгэлтэй залуу. Хөвүүнийг өөрөө тийш нь аваад явна, тэд нар авахгүй гээд үзэг л дээ!

Алс Дорнод руу явахад тусгай үнэмлэх хэрэгтэй байдаг болж таарав. Варя сэргийлэхийн 8 дугаар хэсэг дээр очсон чинь үнэмлэх авахын тулд ёсчлон бүрдүүлсэн дуудлага байх шаардлагатай, ямарыг “тэнд” мэднэ гэж тайлбарлажээ.

Варя тэр даруй Максимд цахилгаан явуулав: “Засгийн шагнал хүртсэнд баяр хүргэе (яадгийм, ингэвэл цахилгаан түргэн хүрнэ). Амралтаа авсан, манай хүү Ваня бид хоёрт үнэмлэх авахад хэрэгтэй дуудлага яаралтай ирүүл. Варя”.

Климент Ворошиловын амьдралд 1938 оны зун тохиосон хоёр сар шиг аймшигтай юм гэж байгаагүй болой. түүнийг хоёр сар Улс төрийн товчооны хуралд урьсангүй, Сталин руу утасдахаар утсаа авахгүй, Сталин зөвхөн жанжин штабын дарга Шапошниковыг дуудаж мэдээ авна. Ворошилов шөнө ч унтахаа больжээ. Босч гал тогоондоо ороод тайвшрах санаатай хүйтэн ус балгана. Юу гээч болдог бол оо? Мянга түмэн цэргийн дарга нарыг баривчилж буудан алсан шиг, Улаан Армийн дээд удирдлагын бараг бүх бие бүрэлдэхүүнийг буудан алсан шиг, Улс төрийн товчооны хэдэн бүрэлдэхүүнийг буудан алсан шиг өөрийг нь баривчлаад буудан алах юм болов уу? Гэтэл энэ бүх баривчлах, буудан алах ажилтай мань Ворошилов өөрөө үг дуугүй санал нэгдэж байсан шүү дээ. Тэдний дотор огт танихгүй хүн ч байсан, эрэлхэг дайчид, авьяаслаг цэргийн дарга гэж мэддэг нөхөд нь ч байсан. Гагцхүү Кобад тал засахын тулд, гагцхүү түүнийг сэтгэл хангалуун байлгахын тулд нэг ч баривчлагыг ганц удаа ч болохноо эсэргүүцээгүй, харин ч маш хатуу гэсгээн цээрлүүлэхийг шаардаж асан. 1919 оноос хойш, Царицынаас хойш хамаг амьдралаа гагцхүү Кобад зориулсан, түүний төлөө үхэр нохой мэт үнэнч зүтгэсэн, аль хориод онд л анх түрүүлэн нөхөр Сталиныг иргэний дайны гол зохион байгуулагч жанжин мэтээр бичсэн, түүнийг үг хэлэх болгондоо алдаршуулж, түүний дайсантай тэмцэж ирсэн. Гэтэл одоо өөрийг нь шөнө ирж бариад, шоронд хаяж, зодож нүдэж, эрүүдэж тарчлааж, бүх юманд албадан гарын үсэг зуруулна. Тэгээд мань ард түмний хайртай хүү, иргэний дайны баатар чинь түүхэнд урвагч, шарвагч, тагнуул болж үлдэнэ. Екатерина Давидовнаг нь, үр хүүхдийг нь бас эрүүдэж тарчлаасны эцэст, эсвэл ална, эсвэл хорих руу тонилгож, тэд нар нь тэнд мод цагаалах ажил дээр мажийна.

Хар аяндаа хоолой зангиран эхэр татна. мань Коба: “Чам руу очих юм бол чи тэднийг битгий оруулал даа!” гэж даажигнаад байсан. Битгий оруул гэсэн чинь юу гэсэн үг вэ?! Хаалга хэмхэлж орж ирээд, гарыг нь ганцхан мушгичихна. Өөртөө сум зоочихдог юм уу? Тэгэх юм бол зүрх нь хаагдаж нас нөгчсөн гэж зарлаад, Улаан талбай дээр хүндэтгэлтэй оршуулна, эхнэр хүүхдэд нь халдахгүй, ард түмний ой тойнд мань хүн анхны улаан офицер байсан чигээрээ дурсагдан үлдэнэ. Өөрөө дөнгөж тавин тавтай, хөндлөнгийн хүн бол дөчин тав, зургаатай гээд байхад энэ сайхан идэрхэн насандаа, эрүүл тэнхлүүн чигээрээ үхэх хэрэг үү. Хөрөг зураг нь ч тийм л ануухан байгаа. Ийм өндөрлөгт хүрчихсэн, улс орон даяараа мэддэг болчихоод байхад үхэх хэрэг үү! Ингээд бүх юм дуусах нь. Ээ-эх, Коба, Коба, чи үнэнч хүмүүсээ даанч үнэлэхгүй юм даа, намайг хэнээр солих гээ вэ – Будённый годилоор уу? Яасан гэж тэр вэ? За яахав, нэгэнтээ болгоомжгүй, гоомой загнаа л биз, гэхдээ гэмт хэрэг биш, өчүүхэн зүйл шүү дээ, чи бид хоёроос өөр хэн ч тэр ярианы тухай мэдэхгүй. Уучилж болмоор сон. Уучлахгүй юм.

Гай болоход Екатерина Давидовна тэгэхэд гэртээ байхгүй байж таараад, Кондратьевынхан Москвагаар дайрч явна гэж утасдахад нь мань хүн ороод гар гэчихсэн билээ. Миша Кондратьев арван есөн онд цагаантны сумыг цээжээрээ хааж аминд нь орсон удаатай, ер нь ч сайн нөхөд...

мань хүн гэрийн эзний ёсоор намбатай гэгч нь хоол унд төхөөрөөд, ширээ рүү сууцгаатал, зочид нь тухайлсан хэрэг зоригоор ирсэн болж таарч, идэж уухын завдалгүй шууд яриандаа

оржээ. Тэдний Сережа хүү нь юунаас, яаж өвдсөнийг бүү мэд, сэтгэл мэдрэлийн өвчтэй, эцэг эх нь яваагүй газаргүй, үзүүлээгүй эмчгүй, эдгэхгүй гэдгээс өөр үг сонсоогүй аж. Тэр хүү нь нэг их догшин ширүүн бус, номхон томоотой, баахан юм шулганаж бувтнахаас цаашгүй. Сэтгэл мэдрэлийн эмнэлэгт даанстай, сүүлийн жил тэнд хэвтээд гарсан, хоёр сарын өмнө картоны үйлдвэрт хайрцаг наах ажилд оруулсан ухаантай, гэтэл тэнд болсон цуглаан дээр мань Сережа “Сталин тонилтугай!” гэж хашгарсан мэт хүмүүс нэг юм зохиочихжээ. Тэр хүүхэд тэгж хашгарах учиргүй, улс төр сонирхдоггүй, бас хэзээ ч хашгарч барьдаггүй, аяархан ярина, өөртөө л нэг юм бувтнаад байхаас биш, үг нь ч сайн мэдэгдэхгүй, хэрэв буруу зөрүү юм хэлсэн бол сэтгэл мэдрэлийн өвчтэй гэдгийг нь бодолцох ёстой. Гэтэл түүнийг баривчлаад, “Террорист үйлдэл хийхийг уриалсан!” хэмээн буудан алах ял заачихсан. Арван зургаахантай хүүхэд! Климент Ефремович минь, хүүг минь аварч туслаач! Ийм яриа болж.

Иймэрхүү явдал дээр хэнд ч туслах зохисгүйг Ворошилов мэднэ. Хэрэв тэр хүү үнэхээр “Сталин тонилтугай!” (ийм үгийг давтан хэлэхэд ч аймшигтай) гэж хэлсэн бол хэн ч, Вышинский ч, Калинин ч түүний төлөө ганхийхгүй. Тэр нь галзуу ч бай, биш ч бай, том хүн ч бай, хүүхэд ч бай ялгаагүй. Ийм ажил дээр ганцхан Сталин л өөрөө тус болж чадна. Бас сэжүүр ч байна: Сталин Кондратьевынхныг танина, тэднийд сууж байсан, Мишкаг ч мэднэ, Наталья хүүхэнд нь ч нүд алдаж байсан удаатай, даанч тэр үед мань хүүхэн найман сартай урагтай, хөл хүнд байсан нь аварсан, тиймгүй сэн бол Коба түүнийг заяа нь зүгээр орхихгүй байсан. түүнээс гадна түүнд тэр “Сталин тонилтугай!” гэсэн үгнийх нь тухай хэлэхгүй байж болно. Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүүхэд юу ч гэсэн юм, нэг бувтаначихсан чинь алах ял заачихаж гэх маягаар хэлчихгүй юү.

Тэгээд мань хүн туслахаар амалжээ. Наталья хоёр хар нүд нь царайчлан харахад, тэр харцанд нь ямар их горьдлого, шаналан байгааг олж үзээд, хуучны дурсамж ой ухаанд нь үерлэн ирэхүйд мань хүн түүнд бүхнийг чадагч болж харагдмаар санагдан: “За яахав, багачуул минь, битгий уй гашуу болцгоо, туслахыг бодъё, учрыг нь олъё” гээд хэлчихжээ.

Цаадуул нь тийнхүү горьдлого өвөрлөн яваад өгч. Харин Ворошилов баахан эрэгцүүлж бодоод, ийм явдлаар ийш тийш гүйх аюултай, тэдэнд дэмий гордлого төрүүлсэн байна гэж шийджээ. Бас Екатерина Давидовна гэртээ байгаагүй нь даанч тоогүй, байсан бол Кондратьевынхныг ир барь гэхгүй, юмханаар арга саам хийгээд энэ хэргийн тухай мэдэхгүй өнгөрөх байсан гэж харамсжээ. Хамаг юм санамсаргүй болчихсон, тэгсэн чинь бас нэг учрал дахиад хөөдчих нь тэр.

Хэд хоногийн дараа Сталинтай сууж байж. Сталин сэтгэл санаа урамтай байснаас гадна, яагаад ч юм бэ, тэр хоёр Царицыны тухай дурсаж байсан тул мань Ворошилов гэнэт ингэж асуужээ:

- Коба, Кондратьевынхныг санана уу?
- Ямар Кондратьевынхан?
- Царицынд чи тэдний гэрт сууж байгаагүй юү.
- Зүгээр сууж чаддаггүй залуухан хоёр уу, эхнэр, нөхөр хоёр?

– Яг тэр чинь. Тэд нар.

– Тэд яаж шуухан байдаг бол?

– Дажгүй ээ. Нөхөр нь Барилгын банкинд ажиллаж байгаа, авгай нь техникумын захирал.

– Мэнд уламжлаарай.

– Тэднийд бөөн гай тохиочихож.

– Юун гай билээ?

– Хүү нь хар багаасаа сэтгэл мэдрэлийн өвчтэй, эмнэлэгт бүтэн жил хэвтээд сая гарсан ч тэртэй тэргүй өвчтэй, галзуу юм.

– Юугаар туслаж болох юм бол?

– Яаж туслах вэ дээ? Эдгэрэшгүй өвчтөн. Өөр юмаар туслууштай байна. Юу болсон гээч, тэр хүү цуглаан дээр нэг юм хашгарчихсан чинь барьж аваад алах ял заачихсан гэнэ. Нас нь арван зургаа. Эмнэлгээс гаргах ёсгүй байхад нь гаргачихгүй юу.

– Юу гэж хашгарсан юм бол?

– Юу ч гэсэн юм бэ дээ... Галзуу хүнээс чинь юугий нь авах вэ дээ?

– Чухам юу гэж хашгарсан юм бэ?

– Үгүй ээ, Коба!.. Галзуу хүн юу эсийг донгосох билээ...

Сталин Ворошилов руу харсан чигээрээ:

– Чухам юу гэж хашгарсан юм бэ? гэв.

– Би яаж мэдэх билээ, галзуу хүүхэд... хэмээн Ворошилов сандрав.

– Чи түүний өмнөөс хөөцөлдөхөөр болсон юм бол заавал мэдэж байх ёстой.

– Том танхим. Бөөн шуугиан, тоймтой юм сонссон хүн байхгүй, гэтэл хэн ч юм бэ, хоёр хүн түүнийг: “Сталин тонилтугай!” гэж хашгарсан мэтээр мэдүүлсэн гэнэ. Ворошилов сандарсандаа хөлс нь чийхарч, ийм юмтай орооцолдсондоо өөрийгөө дотроо зүхэв.

Сталин хараагаа буруулж, бодолхийлснээ,

– Бидэнд тийм галзуунууд хэрэггүй гэв.

тэрээр дараа нь шалгасан, тэгээд хөвүүнийг буудан хороожээ. Тэр нь ч зүйтэй. Эс тэгвээс алан хядагч болгон өөрийгөө галзуу хүн гээд зарланихна. Харин тэр галзуу хүү яагаад: “Нөхөр Сталин мандтугай” гэж хашгараагүй юм бэ?! Яагаад өөрийгөө Сталин болгосонгүй вэ?

Галзуу нар чинь өөрсдийгөө Наполеон, Иисус Христ энэ тэр болгоцгоодог шүү дээ. Ямар ч галзуу одоо хир: “Наполеон тонилтугай!” “Иисус Христ тонилтугай!” гэж хашгараагүй байгаа. Мөн хөөцөлдөх хүнээ олов оо! Тэнэг годил! мань ХҮН ийм годилыг дэргэдээ байлгаж, дэвшүүлж байдаг, гэтэл тэр дүйрэн нь ийм юм хөөцөлдөж байдаг! түүнд ийм явдлыг шургуулж байна. Улс төрийн товчооны гишүүн гээд байгаа! Цуглаан дээр нөхөр Сталины хаягаар юу гэж хашгачиж байдгийг үзүүлэх санаатай юм гэнэ!

Сталин хоёр сар Ворошиловыг хүлээж аваагүй. Юу хүлээж байгааг мэдэхгүй нэг хэсэг яваг, толгойгоо жаахан ажиллуулаг.

Бодохоос өөр хийх юм үлдсэнгүй. Батлан хамгаалахын ардын комиссарын албанаас зайлуулсангүй, өдөр болгон ажил дээрээ очно, коллегийн хурлаа хийлгэнэ, цэргийн тойргийн коамндлагчид, төрөл цэргийн командлагчдыг хүлээн авна, тушаал захирамж буулгана. Засгийн газрын гишүүний хувьд Совнаркомын хуралдаанд оролцоно, бусад ардын комиссар, түүний дотор Молотов, Каганович нар юу ч өөрчлөгдөөгүй, юу ч болоогүй юм шиг хуучин янзаар үгийг нь сонсоно, Улс төрийн товчооны гишүүнд ирүүлэх ёстой бичиг баримтыг ёсоор ирүүлнэ. Гэхдээ нэгэнт өнгөрсөн хүнтэй ингэж тоглодог сталинч тоглоомыг Ворошилов сайн мэднэ.

Ворошилов хүүхдүүддээ юу ч хэлээгүй, харин Екатерина Давидовнад ярьсан ажээ. Гэхдээ Кондратьевыг ганцаараа ирнэ гэж бодсон чинь эхнэртэйгээ ирсэн гэж хэлжээ. Екатерина ухаантай хүүхний хувьд тэр өчүүхэн зүйлийг тоосонгүй. Тэгээд уймарч сандрах хэрэггүй, болох юм л болно биз гэж хэлжээ. Гэхдээ эрүүдүүлж тарчилж байснаас үхсэн нь дээр гэдэгтэй санал нийлжээ. Хэрэв тэднийг барихаар гэр рүү нь ирэх юм бол хоёулаа өөрсдийгөө буудаж хорооно, хэн хэн нь гар буутай. мань хүнийг барихаар ажил руу нь ирэх юм бол албан өрөөндөө өөрийгөө хороох хэрэгтэй, өөрөө гэртээ амиа хорлоно. Хүүхдүүдийг хөндөх хэрэггүй, томчууд нь өөрсдийнхөө хувьд бүх юмыг өөрсдөө шийднэ. Тэгээд нөхрөө үнсэж, үхэхдээ хүрэх юм бол тайван үхнэ, хамт өнгөрүүлсэн амьдралынхаа төлөө талархаж байгаа, аз жаргалтай байсан гэж хэлжээ. Ворошилов эхнэрийнхээ цээжийг налан хэдэн нулимс унагав. Эхнэртээ хайртай, өөрийг нь хэзээ ч хөөдөж байгаагүй, Кремлийн дээдчүүлийн хүрээ рүү зүтгэлэхгүй, гэр орныхоо ажил, хүүхэд шуухдаа болгоохын хамт, өөрийнх нь унших номыг сонгож олно, хөгжимд дуртай болохоор өөртэй нь цуг явж дуурь сонсоно, пянз цуглуулна, өөрийнх нь уран зураг сонирхдогийг хөхиүлэн сайшаана, үзэсгэлэнгээр дагуулж явна, хэзээ ч элдвээр өөчилж гоочлохгүй. Цэргийн мэрэгжилтний хэрэг гэж гарсан, бас Тухачевский болон цэргийн бусад дарга нарын хэрэг гэж гарсан, тэр бүхэнд эхнэр нь ер оролцоогүй, дуугүй л байсан, жинхэнэ сайн эхнэр. Ер нь улс төрийн бодлогын талаар бараг хэзээ ч юм ярихгүй, хааяа юм хэлж гэмээнэ яг голоор хэлнэ! Бас энэ удаа ч алдсангүй, ийм л хүүхэн дээ!

Есдүгээр сарын 30-нд Ворошиловыг үдийн хоолоо идэхээр гэртээ ирэхэд (голдуу гэртээ үдийн цайгаа уудаг юм) Екатерина Давидовна,

– Мюнхений хэрэг явдлыг чи мэдэж байгаа юу? гэж асуужээ.

– Радиоогоор нэг юм дамжуулаад байсан, ямар нэг хэлэлцээр байгуулсан ч юм шиг. Сонин дээр юу ч л алга байна.

– Сонинд маргааш гарна. Өнөөдөр мэдэхийг хичээгээрэй. Би үүнийг маш ноцтой гэж бодож байна, энэ бол дайн ч байж магадгүй. Одоо түүнд чи зайлшгүй хэрэг болно.

Ворошилов ардын комиссариатгаа эргэж ирээд сүүлийн улс төрийн мэдээний тоймыг шаардаж үзээд дараах зүйлийг мэдэж авав.

1938 оны есдүгээр сарын 30-ны шөнө Мюнхенд Герман, Итали, Англи, Франц гэсэн Европын дөрвөн улсын тэргүүн Гитлер, Муссолини, Чемберлен, Даладые нар хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Чехословак Судет муж болон түүнтэй хил залгаа германууд суудаг бүс нутгийг нэн даруй Германд шилжүүлэхийн хамт Польш, Венгерийн зүгээс нутаг дэвсгэрийн талаар тавьдаг шаардлагыг хангах ёстой болжээ. Ингэснээр Чехословак нутаг дэвсгэрийнхээ тавны нэг, хүн амынхаа дөрөвний нэг, хүнд аж үйлдвэрийн болон баруун талынхаа хамгаалалтын лут лут байгууламжийнхаа тэн хагасаас тус тус салж байгаа аж. Германы шинэ хил Чехословакийн нийслэл Прага хотын хаяа хотуудын дэргэдүүр өнгөрнө.

Ворошилов энэ мэдээг дөнгөж уншиж дуустал Улс төрийн товчооны хуралд яаралтай ир гэсэн хэл иржээ.

Екатерина Давидовнагийн зөв болж таарав.

Оройн зургаан цагт Сталины цэлгэр өрөөний ногоон цэмбэн бүтээлэгтэй урт ширээний ард цугларцгаав. Гадаад хэргийн ардын комиссар Литвинов бусдаас жаахан зайдуу суужээ.

Бүдэг хүрэн френчтэй, мөн тийм өнгийн өмднийхөө шуумгийг гуталдаа чихэж өмссөн Сталин хуучин янзаар цонхон талаар бус, ЗСБНХУ-ынхаас гадна одоо Европын газрын зураг өлгөсөн ханын дагуу өрөөн дотуураа хөлхөх аж. Тэр зураг дээр туслах нар нь Герман, Чехословакийн шинэ хилийг тэмдэглэж, Герман, Польш, Венгенийн Чехословакаас булааж авсан газрыг ойрхон зураасаар эрээлжээ. Сталин зурагны хажууд ирэх бүрийдээ түүнийг ажиглан зогтусч, Чемберлен, Даладьё нарын хаягаар: “Урвагчид, хулчгарууд, панзчингууд” хэмээн ууртай өгүүлж байв. Харин Гитлерийг эс доромжлох аж. Гитлер өөрийнхөө юмыг авсан, гарт нь аяндаа орж ирж байхад авалгүй ч яахав. Польшууд бол бас дэлт бүргэд, Тешиний Силезийг булаагаад авчихсан байна. Бортоготой аалзнууд! Муусайн чехүүд хулчийсан байна.

Сталин Ворошиловтой дөнгөж өчигдөр уулзсан мэт ердийн байдлаар мэндлэв. Цаадахынх зүрх хоолойгоороо гарчих шахаж. Гайгүй өнгөрлөө чух даа! түүнд амь насыг нь бэлэглэж, хамаг аймшигт юм ард нь хоцорлоо, Сталин хилэнгээ ивээлээр солилоо.

Дараа нь нэг давхраар доошилцгоон, оройн хоол идэх зуур яриагаа үргэлжлүүлэв. Багтраатай Жданов гадаадын цахилгаан мэдээний агентлагуудын орос руу орчуулсан сүүлийн үеийн мэдээнүүдийг амьсгаадан тайлбарлалаа:

– Чехословакийн төлөөлөгчид үүдний өрөөнд өдөржин хүлээсэн байна. Тэднийг шөнийн нэг хагас болж байхад дууджээ. Гитлер, Муссолини хоёр нэгэнт явчихсан байж. Чемберлен чехийнхэнд хэлэлцээрийн тухай тайлбарлаад, өөрсдөө унш гэх маягтай гардуулж өгчээ. Чехословакийн төлөөлөгч тэд нараас засгийн газрынх нь хариуг хүлээж байгаа эсэхийг асуухад, цаадуул нь ямар ч хариу хэрэггүй, энэ бол эцэслэсэн хэлэлцээр, Чехословак 1918 оныхоо хилээр оршин байгаа больсон гэж хэрцгий нь аргагүй хариулжээ. За тэгээд... Сонсоцгоо доо, яасан гээч... Чехословакийнхантай ярьж байхад Чемберлен зогсоо зайгүй эвшээж байсан байна...

– Яг Британийн ихэмсэг зан хэмээн Сталин өгүүлэв. – Би тэр Чемберлений чинь зургийг, яаж байгаад ч билээ, сонингоос нэг удаа харсан, нэг муу жижигхэн толгойтой, арьс яс болсон жигтэйхэн гонжийсон этгээд, ухвараас олддог эртний амьтан л гэсэн үг. Тэр амьтныг юу гэдэг билээ дээ, мартчихаж...

– Нисдэг гүрвэл гэж Жданов хэлж өгөв.

– Яг тийм гээд Сталин зууш руугаа эргэв.

Ширээн дээр шарз, архи, утсан шүхэрлэг хилэм, түрс, мөөг, талх, ямар нэг ногоо, элдэв амттан тавилжээ. Ямар ч хиам, утсан мах, нөөш алга, Сталин тийм юм ерөөсөө иддэггүй. Хрущев нэг хурган хэмх сэрээдэн Андреевт харуулах зуур: “Тэр Чемберлений чинь толгой шиг” гэхэд бүгдээрээ инээлдэв. Ворошилов Улс төрийн товчооны бусад гишүүдийн адил

жаахан зууш тавгандаа хийсэн боловч айгаад дарс аягалсангүй. Сталин түүн рүү хялайж,

– Маршалуудад ч гэсэн хундага дарс болно шүү дээ гэв.

Ворошилов талархсандаа малилзан царай орж, өөртөө дарс хундагалав.

Нөгөө ширээн дээр нэгдүгээр хоолтой том сэнжтэй хэдэн хувин, хажууд нь цэвэрхэн тавагнууд давхарлан тавьжээ. Хүн болгон очиж, хүрэн манжингийн шөл, цулгуй шөл энэ тэрээс дуртай дуртайгаа аягалан авч байв.

Сталин сэнжтэй хувингийн тагийг сөхөн харж, хэнд ч хандалгүй,

– А-хаан, байцааны шөл... Өө, энд гоймонтой шөл... Загасны шөл... Загасны шөл идэх минь гэв.

Тэгтэл ч Ворошилов түүний араас загасны шөл өөртөө яаравчлан аягалав.

Дараа нь зөөгч нар хоёрдугаар хоолтой түмпэн авчирлаа. Төгсгөлд нь халуун тогооноос цай ууцгаав.

Сталин албан өрөөнд өмссөн байсан френчтэйгээ хэвээр ч, зөөлөн савхин гутал өмсчээ. Энэ байранд нь шинэ хилийг тэмдэглэсэн газрын зураг бас өлгөсөн байж. Сталин албан өрөөнд байсан шигээ энд бас газрын зураг руу байн байн очиж өмнө нь зогсоод, Чемберлен, Даладьё нарын “мюнхенчүүдийг”, Англи, Францыг зүхэж байв.

Маргааш нь зургаан цагт Сталины албан өрөөнд дахин цуглаж, хуралдаанаа дахиад түүний гэрт оройн хоол идэнгээ дуусгажээ. Энэ үес шинэ мэдээнүүд иржээ: Прага хотын оршин суугчид армия хилээс татахгүй байх, бүх нийтийн цэргийн дайчилгаа зарлахыг шаардан гудамжинд гарцгааж, хүмүүс уйлалдаж байж. Гэтэл Чехословакийн засгийн газар бууж өгч байгаагаа аравдугаар сарын нэгэнд радиогоор зарлав. Мөн тэр өдөр нь Германы цэрэг хил нэвтрэн Чехословакийн нутаг дэвсгэрт цөмрөн оржээ.

Улс төрийн товчооны гишүүд хамаг уураа Литвиновт гаргацгаалаа.

Ялангуяа Молотов Литвиновт засгийн газрын ганц биеэ даасан хүн хэмээн дургүйг ч хэлэх үү, гойд хичээх аж. Одоо түүнийг бут ниргэх боломж гарах нь энэ. тэрээр: Англи, Францын талыг ямар ч бодлогогүй баримжаалж, энэ империалист араатангуудад сохроор итгэсэн Литвиновын бодлого ийм л юманд хүргэлээ! Нөхөр Литвинов, мэдээж, олон жил Англид суусан, өөрийгөө англи соёлтой хүн гэж үздэг, оросоосоо англиар илүү ярьдаг, англи авгайтай хүн, гэхдээ энэ бүхэн ийм харалган бодлогын үндэс болох ёстой гэж үү? Энэ бол нам бус, бэртэгчин үндэс гэснээ их л сайндаа бэртэгчин үндэс гэж айхтар учиртай засч өгүүлэв.

Каганович цэвдэг цэнхэр нүдээрээ Литвиновыг адлан харж, өрнөдийн хөрөнгөтний өмнө хямдхан нэр хөөцөлдсөөр Зөвлөлт Холбоот Улсын ашиг сонирхлыг хөсөрдүүлээ гэж буруушаав. Мюнхений явдлыг яагаад урьдаас харсангүй вэ, яагаад тааварлаж мэдсэнгүй вэ?

Намын удирдлагад яагаад урьдчилан мэдэгдсэнгүй вэ? Литвинов болон түүний аппаратынхны талаар хайр найргүй хатуу дүгнэлт хийх хэрэгтэй.

Болгоомжтой Микоян ад тачаалын гаарлыг жаахан дарж өгөв. тэрээр ЗСБНХУ-ын Өрнөдтэй хийж буй худалдааны байдлын талаар, Германы тал харилцан хийх худалдаа-зээлийн хэлэлцээрийг сунжруулж байгаа талаар ярих.

Айдас нь хараахан бүрэн арилаагүй Ворошилов бусадтай дуу хоолойгоо нийлүүлэв. тэрээр Сталин руу айдсын харц шидлэх зуур зөвлөлтийн болон чехословакийн зэвсэгт хүчний талаарх тоо баримтыг уншлаа. Германы 43 дивизийн өөдөөс ЗСБНХУ, Чехословак хоёр 133 дивиз шууд гарган тавьж чадна. Бараг гурав дахин илүү хүч, Гитлер нэн даруй ялагдал хүлээх болно. Гэтэл зөвлөлтийн хүчирхэг дэмжлэгийг Чехословакт итгүүлэхийн оронд Литвинов Англи, Францтай сээтэгнэж, цаадуул нь түүний ар худрагаар Германтай хуйвалдчихсан байна.

Литвинов тайван ярьж байна. Англи, Франц хоёр урван тэрсэлж байгаад Гитлерийг номхруулах гэж байгаа нь үнэн. Тэдний горьдлого ямар ч үндэсгүй. Гитлер ихээхэн алсын төлөвлөгөөтэй байгаа. Гитлерийг шинэ түрэмгийлэл үйлдээд эхлэхээр түүнийг зогсоох ёстой, эс тэгвээс өөрсдөө золиос болохоо тэд ойлгоно. Тийм учраас тэд ЗСБНХУ шиг холбоотноо алдах ёсгүй. Нөхцөл байдал хүнд байгаа ч гарцгүй явдал биш. Ухаан жолоогоо алдах хэрэггүй. Мюнхений хэлэлцээрийг хүчтэй эсэргүүцэгч Өрнөдөд бий. Чемберлен Лондонд эргэж ирээд: “Би энх тайвныг авчирлаа” гэж зарласан. Үүнийх нь хариуд Уинстон Черчилль: “Бид бүрэн хиар цохиулсан ялагдал хүлээлээ. Үүгээр бүх юм дуусна гэж бас горьдохын хэрэггүй. Энэ бол зөвхөн эхлэл” гэж хэлсэн. Энэ байр суурь бол ганц Черчиллийнх биш, олон ийм санаа бодол Европт ноёлож байна.

– Та Гитлерийг ЗСБНХУ руу довтолж мэднэ гэж үзэж байна уу? хэмээн Молотов үгэн дундуур нь оров.

– Англи, Франц хоёрыг тэр илүү хялбар өрсөлдөгч гэж төсөөлж байгаа. Хэрэв тэр Европын дайн дэгдээнэ ээ гэвэл эхлээд тэр хоёр руу дайрч байж, дараа нь манай руу дайрна.

– Та манай сонор сэрэмжийг сулруулж байна. Хэний эрх ашгийн төлөө ингэж байна? гэж Каганович бүдүүлгээр дайрав.

– Надад миний эх орон, миний намын эрх ашгаас өөр эрх ашиг байхгүй.

– Хоосон үг! гэж Каганович хэдэрлээд буруу харав.

Сүүлчийн хуралдааны төгсгөлд Сталин үг хэлэв. Гэхдээ Улс төрийн товчооны гишүүд түүнээс сонсоно гэж бодож байснаасаа шал өөр юм сонсчээ.

– Англи, Франц хоёр Гитлерийг Зөвлөлт Холбоот Улсын эсрэг түрэмгийлэл хийлгэх гэж турхирч байна. Зөвлөлтийн эсрэг эвсэлд Япон нэгдчихлээ, ЗСБНХУ улс төрийн аюултай тусгаарлалд орж таарлаа гэж Сталин хэлэв.

тэрээр босч, урьдын адил цонхны дагуу нааш цааш холхин, Кремлийн гэрлийг харах зуур үргэлжлүүлэн ярилаа.

– Ийм нөхцөлд юу хийвэл зрхих вэ? Гитлер өрнөдийн гүрнүүд рүү довглоно гэж нөхөр Литвинов бидэнд батлан хэлж байна. Тийм хувилбарыг үгүйсгэхгүй, гэхдээ үүнийг юуны өмнө өрнөдийн гүрнүүд өөрсдөө ойлгох ёстой гээд Сталин Литвиновын хажууд зогтусч, түүн рүү хуруугаа занган, – Нөхөр Литвинов, та хэрэв Гитлерийн довтолгоонд Англи, Франц хоёр нэрвэгдэнэ гэж итгэл төгс байгаа бол та өөрөө Англи, Францын удирдагчдад үүнийг итгүүлэх ёстой. Манай дипломат албаны үндсэн зорилт одоо чухам үүнд оршино гэв.

Литвинов, Гадаад хэргийн ардын комиссариатын ажилтнууд Сталины удирдамжийг махран хэрэгжүүлж байв.

Гэтэл Сталин өөрөө зөвлөлтийн дипломат албаны үндсэн зорилтыг тэс өөрөөр ойлгож байжээ.

Англи, Францын дорой байдлыг, тэдний Гитлерээс айж байгааг Мюнхений хэлэлцээрийн дараа хэн хүнгүй харцгаалаа. Тэгэхээр энэ байдал Гитлерийг “үүрдийн дайсан” Францынхаа эсрэг, үзэн яддаг Английнхаа эсрэг довглох зүгт түлхэнэ. Гэхдээ Гитлер ар талдаа найрсаг буюу дор хаяхад төвийг сахьсан Зөвлөлт Холбоот Улстай байж гэмээнэ тэдэн рүү дайрна. Үүнийг Литвинов ойлгохгүй, тэгэхээр ЗСБНХУ-ыг Германтай ойртуулах ажлыг хэрэгжүүлэхгүй. түүний оронд энэ ажлыг өөр хүмүүс хийж байгаа. Харин Литвинов Франц, Англи хоёртой хэлэлцээ хийж, тэдний сонор сэрэмжийг бөхөөж байг.

Гитлер еврей Литвиновын огцрохыг сайн хүлээж авах нь дамжиггүй. Гитлер, ТЭР хоёрын харилцаа зохих түвшинд хүрмэгц тэрээр түүнийг огцруулчихна. Гэхдээ устгахгүй. Юм яаж эргэхийг бүү мэд, Литвиновын хэрэг дахиад гарч мэднэ. Англи, АНУ-д түүний нэр хүнд сайн байгаа, тэднийгээ үргэлжлүүлэн ятгаж байг. Жинхэнэ бодлогыг, түүний бодлогыг өөр хүмүүс явуулж байгаа. Германд суугаа худалдааны төлөөлөгч Канделаки нууц хэлэлцээ хийж байгаа. тэрээр Литвиновт бус, ӨӨРТ нь биечлэн хандаж байгаа. Нууц хэлэлцээний тухай одоо Молотовт мэдэгдэх хэрэгтэй.

Лена утасдлаа.

– Варенька, чадмаар бол бушуухан хүрээд ир, аль болохоор түргэн шүү.

– Одоо очлоо...

Варя утсаа тавиад Игорь Владимирович руу очив.

– Игорь Владимирович, надад явах хэрэг гарлаа.

Цаадах нь түүн рүү гайхшран харав. Нэг цагийн дараа тэд Москва хотын зөвлөл рүү очих ёстой, Варя түүний илтгэх зүйлийг бэлтгэсэн, тийм болохоор урьдын адил цуг явах учиртай.

– Манай гэрт яалт ч үгүй ажил гарлаа. Би юм хумаа Левочкад тайлбарлаад өгчихье, тэр тантай хамт яваг, тэгэх үү?

– За тэгж байгаа бол Лева хамт яваг гэж Игорь Владимирович зөвшөөрөв.

Ленаг, тэдний гэрийн бүх хүнийг гурав хоногийн дотор Москвагаас гарч явахыг үүрэгдсэн бичиг өгсөн болж таарав. “Хаашаа явах хүсэлтэй вэ?” гэж асуухад нь Лена Варягийн зөвлөсөн дагуу Мичуринскийг нэрлэжээ. “Мичуринск болохгүй”. Тэгэхээр нь өөр хотын нэр толгойд орж ирээгүй учир Уфа гээд хэлчихэж. Тийм учраас Уфаг бичиж өгөөд, төмөр замын тасалбар өгсөн байна. “Би хүүхэдтэй”. – “Хэдтэй юм бэ?” – “Ой хагастай”. – “Тусдаа тасалбар шаардлагагүй”. Ийнхүү Лена нөгөөдөр Уфа руу явах ёстой, очоод тэндхийн ДЯАК-ын газар бүртгүүлэх учиртай, хэрэг явдал ийм болж. Гэрийн үйлчлэгч Маша өнөөдөр ажлаасаа чөлөөлөгдөж, Метрострой-д шилжиж, тэнд нь нийтийн байранд оруулна. Дүүгээ хүүхэд асрах аль газар очсоныг Машад итгэмжлэх авч мэдүүлэх санаатай байна. Тийм итгэмжлэх өгөх эсэхийг бүү мэд.

– Би яваад Владленийг аль газар өгснийг хуу мэдчихье, тэгэх үү?

– Варенька минь, хөндлөнгийн хүнд ямар ч лавлагаа өгдөггүй юм. Тэд нар тийм дүрэмтэй. Харин Маша бол дор хаяхад паспортоо үзүүлнэ, тэр манайд, Грановскийн гудамжинд байхад ч, энд ч бүртгэлтэй байсан юм. Энэ нь тус болж магадгүй.

– За яахав, Маша олж мэдэг, гэхдээ суун тусья, чамтай яримаар юм байна гэж Варя өгүүлэв.

Тэр хоёр суулаа.

– Уфа гэдэг чинь сайн болж, тэнд Сашаг чи олно, тэр чамд туслана.

– Үгүй ээ, би Сашаг хайхгүй, түүнийг төвөгтэй байдалд оруулахыг хүсэхгүй байна.

Нөгөөтэйгүүр эд нар хотыг санаандгүй сонгуулж байгаа юм биш, тэгтлээ хүнлэг хүмүүс огт биш. Тийм байдлаар хэнд, хаана хамаатан садан байна гэдгийг мэдэж аваад, дараа нь дахиад баривчлах, цөлөх шинэ ээлж эхлүүлэх санаатай гэж надад бодогдоод байна.

– Энэ бол чиний хэрэг. Харин Ваняг бол чи өөртэйгөө авч явах эрх байхгүй. Чамайг тэнд шоронд хийчих юм бол хүү чинь балрана, хийхгүй бол та хоёр хоёулаа балрана.

Лена духайсхийн түүн рүү харлаа.

– Чи яа гэж байгаа юм?

– Нина хэнтэй суугаад, хаашаа явчихсан тухай чи бодож байсан уу, хэлээч?

– Варенька минь, тааж цөхөх юу байна. Макстай суугаад, түүн рүү яваад өгсөн биз.

– За тэр шүү. Хасан нуурын тулалдаанд оролцсоны төлөө Макст Зөвлөлт Холбоот Улсын баатар цол олгосон.

– Өө тийм үү? хэмээн Лена сэргээд ирэв. – Би түүний төлөө баяртай байна. Макс ёстой сайн залуу байсан. Эгэл, даруухан, Саша түүнд их сайн байв даа. Үгүйдээн тэр маань хэрэг төвөгт ороогдолгүй үлдсэн нь яамай шүү.

– Ваняг надад үлдээчих, би Нина, Макс хоёр дээр аваачаад өгчихье, ийм санал байна гэж Варя үнэмшилтэй өгүүлэв. – Тэр хоёр түүнийг үрчлээд авчихна, тэднийд Ваня аюулгүй байх болно. Хүүхдээ тэгж аврая, түүний амьд мэнд байгааг, хаана байгааг чи мэдэж байх болно. Тэгээд чиний нөхцөл байдал сайн тал руугаа эргэх юм бол та нар учраа олно биз. Шаардлага гарвал би яваад хүүг чинь чамд авчраад өгнө.

Лена доошоо тонгойн удаан бодсоны эцэст,

– Тэр хоёр хүүг минь авах болов уу? гэж асуув.

– Хормын төдий ч эргэлзэхийн хэрэггүй. Би бүх ажлыг үүрч, хамаг хариуцлагыг хүлээнэ. Хүүхэд бид хоёрт үнэмлэх авахад хэрэгтэй дуудлага ирүүл гээд би хэдийн цахилгаан явуулчихсан байгаа. Би ээлжийнхээ амралтыг авсан. Дуудлага иртэл Ванятай цуг байя, надад Софья Александровна нэмэр болно. Чи ердөө хүүгийнхээ юм хумыг л эмхэлчих.

Лена толгойгоо гудайлгасан чигээрээ суусаар. Эцэг, эх хоёрыг нь буудаад хороочихсон, дүү нь ДЯАК-ын хүүхэд хуваарилах газар оччихсон, одоо ингээд хүүгээсээ салах нь, аягүй бол, үүрд байх, өөрийг нь эцэг эхийнх нь хувь заяа хүлээж байгаа. Үгүйдээн хүү нь аврагдаж үлдэг.

Ээ тэнгэр минь, энэ эрэлхэг зоригтой, биеэ боддоггүй бүсгүй газрын хаанаас өөр дээр нь ирэв ээ? Энэ хорон санаатай, цуст ертөнцөд яаж үлдсэн юм бол оо?

– Би чамд Нинагийн хаягийг өгнө, гэхдээ чи битгий бичиж ав, тийш нь захиа бичих хэрэггүй. Зүгээр цээжилчих. Тэнд бол арми, тэд зовохдоо хүрвэл хүү чинь ч зовох болно. Надаар дамжуулан захидлаар харилцана. Надад өөрөө хүлээн авагч гэж бичнэ. Тэр нь илүү амар, илүү найдвартай.

– Тэгж тохирлоо, чамд өөрөө хүлээн авагч гэж бичиж байя.

Лена гунигтай инээмсэглэн чимээгүй байзнаснаа, Варяг харав.

– Варя, чи яасан сайн хүн бэ! Чи үүнийгээ үгүйдээн өөрөө мэдэх үү?

Берлинд сууж байгаа сурвалжлагч нар 1939 оны нэгдүгээр сарын 9-нд эзэн хааны тамгын газрын шинэ барилгыг урд өдөр нь нээсэн тухай мэдээ дамжуулав. Өмнөх барилгаасаа хэдэн арав дахин том болсон хэмжээ дамжааг нь тоочиж, гантигаар хийсэн аврага баганууд болон дотоод талбайг нь бүрсэн мөн гантиг хавтангууд, гол танхимд орох таван метрийн өндөртэй нүсэр хаалга энэ тэрийн тухай мэдээллээ. Тэр хаалгыг Гитлерийн тушаал ёсоор Версалийн үзэсгэлэнгийн танхимынхаас хоёр дахин том хийсэн гэнэ. Тамгын газрын барилгын нээлтээр дипломат корпуст зориулан нижгэр хүлээн авалт хийжээ.

Гэхдээ сонины мэдээнд байгаа гол юм нь хүлээн авалтын үеэр Гитлер зөвлөлтийн элчин сайд Мерекаловтой и л э р х и й удаан ярилцаж байсан явдал байв. Гитлерийн дараа Мерекалов руу Риббентроп, генерал Кейтель хоёр очсон аж. Зөвлөлтийн элчин сайд анхаарлын төвд орж таарчээ.

Мерекалов Москва руу болгоомжтой даруухан мэдээлжээ: “Гитлер мэнд мэдэлцээд, Берлиний аж төрлийн тухай, мөн миний Москва явсан тухай асуугаад, Германы элчин сайд Шуленберг бид хоёрын Москвад уулзсаныг мэдэж байгаагаа хэлээд амжилт ерөөсөн”. Сталин Мерекаловын болгоомжтой байгаад гайхсангүй: нууц уулзалтын талаар тэр мэдэхгүй, нэмэрт нь герман хэл муу мэднэ, Гитлер түүнтэй хэлмэрчгүй ярьсан байгаа. Гэхдээ энэ баримтын ач холбогдол ойлгомжтой. Гитлер түүнд: мань хүн нууц уулзалтыг мэдэж байгаа, түүнийг сайшааж байгаа, Зөвлөлт, Герман хоёрын харилцааг сайн тал руу нь өөрчлөхөд бэлэн байна гэсэн дохио өгч байна.

Үүний нотолгоо нь Германы хэвлэлд Зөвлөлтийн удирдагч нарыг дайрахаа больсон явдал юм.

Гэтэл үүнээс ч чухал нотолгоо Сталины ширээн дээр тавьсан мэдээнд байжээ. Германы нисэх хүчний яаманд үйл ажиллагаа явуулдаг Шульц – Бойзений фашистын эсрэг бүлэглэлийн тэр мэдээнд: Гитлер гуравдугаар сарын наймны өглөө генерал, адмиралуудын өмнө үг хэлэхдээ, Чехословакийн үлдсэн хэсгийг гуравдугаар сарын арван тавнаас оройтолгүй эзлэж авах; намар болж, зам харгуй боогдохоос өмнө Польшийг эзэлж авах; дөч – дөчин нэгэн онд багтаан “үүрдийн дайсан” Францыг газрын хөрснөөс арчиж, Англид ноёрхлоо тогтоон, түүний баялаг, даян дэлхий дэх эдлэнг булаан авахыг тус тус тушаажээ.

Сталин өөртөө баяр хүргэж болох нь. түүний тавьсан мэргэ зөв болж таарлаа: Гитлер Францыг ониллоо. Одоо түүний үгээ хэлэх л үлдлээ. Тэрхүү хариу үг нь хоёр хоногийн дараа, 1939 оны гуравдугаар сарын 10-нд намын Арван наймдугаар их хурал дээр Сталины тавьсан илтгэл болжээ.

Арван наймдугаар их хуралд бэлтгэхдээ Сталин гол анхаарлаа шинээр сонгогдох намын Төв Хорооны бүрэлдэхүүнд хандуулжээ. Арван долдугаар их хурлаас сонгогдсон ТХ-ны гишүүдийн жагсаалтыг үндэс болгон аваад, буудан авагсдын нэрсийг дарж (тэд олонх нь болсон), буудуулах нь зайлшгүй хүмүүсийн нэрсийн ард палигар чагт тавьж, зарим нэрийг дүүжлүүрийн гогцоо зурах мэт харандаагаар дугуйлаад доош нь орлогч руу оруулж, бусад заримыг орлогч гишүүнээс жинхлүүлэх утгаар мөнхүү дүүжлүүрийн гогцоогоор дээш нь

татаж, өөрийн тооцооны дагуу шинэ нэрсийг нэмлээ.

Харин Арван наймдугаар их хурлынхаа илтгэлд нэмэлт хийх зүйлийг дуудаж бичүүлэв. Англи, Франц хоёр Германд няцаалт өгөөгүйг тэмдэглээд Сталин ийн хэлэв:

“Гол шалтгаан нь... Германыг Зөвлөлттэй дайтан орооцолдоход нь саад хийхгүй байх, дайтагч бүх талыг дайны замгаар хэрэх, тэдэнд бие биенээ тамирдуулж туйлдуулах боломж олгох, дараа нь тэднийг чамгүй туйлдмагц шинэ хүчтэйгээр тайзан дээр гарч ирж, дайны сульдсан оролцогч нарт өөрийн болзлыг тулгах хүсэл. Хямдхан ч, өхөөрдөм ч!.. Гэхдээ энэ улс төрийн осолтой, том тоглоом тэдний хувьд ноцтой алдаа болж төгсөж болохыг хэлэх зайлшгүй шаардлагатай”.

Сталины хариуг Берлинд ойлгожээ.

Гуравдугаар сарын арван таванд Германы цэрэг Прага руу орлоо. Чехийг “Богемийн, Моравийн протекторат” нэрээр Германы эзэнт гүрэнд оруулав. Үүний араас Германы цэрэг Литвийн Клайпеда (Мемель) боомтыг булаан эзлэв. Гуравдугаар сарын 23-нд Мадрид бууж өгч, бүгд найрамдах Испани ялагдал хүлээв. Испанийн нутаг дээрх ЗСБНХУ, Герман хоёрын байлдааны ил сөргөлдөөн зогсов.

Ийнхүү, Гитлертэй холбоо тогтоох зам нээгдлээ. Гэхдээ фашист Германтай холбоо тогтоох хэрэг үү?! Энэ алхмын улс төрийн алдагдлыг хамгийн бага хэмжээнд болгох хэрэгтэй.

Ард түмэн юу гэх бол? Ард түмэн бол улс төрийн хүч биш. Ард түмэн гагцхүү улс төрийн удирдагчийн гарт л улс төрийн хүч болно. Улс оронд улс төрийн хүчтэй сөрөг хүчин байж гэмээнэ огцом эргэлтийг эсэргүүцэх боломжтой. Тийм сөрөг хүчин алга. Тэр хүчийг устгасан, үндсийг нь үүрд тасалсан. тэрээр ард түмнийг удирдаж байна, ард түмэн түүний санамсаргүй эргэлт, арга саамд дассан. түүний гарт нам байна, нам бол төрийг хэрэгтэй зүгт нүд ирмэхийн зуур эргүүлэх чадвартай, үзэгдэж харагдаагүй хүчтэй, дуулгавартай хөшүүрэг. Ард түмэн, хүмүүс бол ердөө л улсын харьяат нар.

Өрнөд юу гэх бол? Өрнөдийнхөн янз янзын хариу үзүүлнэ. Хөрөнгөтнүүд хийрхэж багтрана, социал-демократууд бас тэгнэ. Коммунист намууд түүний гарт байгаа, зөвлөлтийн алтаар аж төрдөг юм чинь. түүний бодлогыг эсэргүүцэгчид өрнөдийн сэхээтний дунд орж таарна. Мэдээж, тэд нарт манлайлагчийн хэрэг гарна. Тийм манлайлагч байгаа. Троцкий. түүнд нэр бий, Октябрийн хувьсгалын баатрын сүр сүлд байгаа, тэр бол өрнөдийн сэхээтний тэгтлээ тэмүүлж буй социализмын биелэл болж байгаа. Тэгээд хамгийн гол нь Сталин, Гитлер хоёрын холбоог өдөр өнжихгүй урьдчилан хэлж байгаа, тэгэхээр том улс төрийн учрыг мэдэхгүй өрнөдийн ажилчин, сэхээтний нүдээр харахад зөвтсөн болж таарна. Троцкий сүүлчийн хэдэн өгүүлэлдээ ингэж бичиж байна:

“Чехословакийн нуралт бол Сталины бодлогын нуралт... Одоо зөвлөлтийн дипломат алба шинэ шинэ ухралт, буултын үнээр Гитлертэй ойртох гэж оролдоно... Сталин, Гитлер хоёр ойртох нь маш том магадлалтай... Сталин намыг түйвээн бусниулж, армийг толгойгүй болгочихоод одоо өөрийнхөө нэрийг Гитлерийн гол төлөөлөгчийн дүрд илэрхий дэвшүүлээд байна”.

Ямар вэ дээ, муу шидэл! Улс төрийн арга саам зайлшгүйг сайтар ойлгож байгаа, тэгсэн мөртлөө түүн рүү угаадас асгаж байна. түүнийг Гитлертэй холбоо тогтоож, тэр муу өчүүхэн IV Интернационал том хүч болж хувирангуут Троцкийн баярласандаа яаж бархирахыг тааж цөхөх юм байхгүй. түүний улс төрийн мэдрэмжийг үгүйсгэх аргагүй, Троцкий ирээдүйнхээ боломжийг маш сайн мэдэрч байна.

Троцкийг устгах явдал өс, хариу авах зорилтоос аюултай эсрэг этгээдийг үгүй хийх зорилт болон хувирч байна. Энэ ажлыг Слуцкий, Шпигельглас хоёрын оронд ДЯАК-д одоо Судоплатов, Эйтингон хоёр эрхэлж байгаа. Тэднийг ажилбараа маш хянуур бэлтгэж байгаа гэж Берия нотлон хэлж байгаа. Мөн ч удаан бэлтгэж байна! Энэ хүмүүстэй ярилцах хэрэгтэй.

Эйтингон эзгүй байгаа аж. Берия Судоплатовтой ирэв. Сталин түүнийг мэднэ: хоёр жилийн өмнө Украины асуудлаар өөр дээр нь ирж байсан. Эмээгээд байсан. Одоо бол арай итгэлтэй харагдаж байна.

Сталин гараа занган, Берия тэр хоёрыг суу гэж дохив. Тэд урт ширээний хоёр талаар сууцгаав. Сталин өрөөн дундуураа холхих зуур аяархан ярьж байв:

– Троцкий манай ард түиэнд хичнээн хор хүргэснийг та нар, мэдээж, сайн мэднэ. түүний холбоотнууд зүй ёсны зэмээ хүртсэн. Гэтэл тэдний толгойлогч? Эсэн мэнд аж төрж байна. Троцкий хилийн чанадад арван жил боллоо. Арван жилийн хугацаанд түүнийг хор хөнөөлгүй болгож үнэхээр чадсангүй гэж үү? Чадах байсан нь эргэлзээгүй. Тэгье гэсэнгүй. Хяхан боогдуулж байсан. Үүний буруутнууд хатуу хариуцлага хүлээх ёстой. Гэхдээ цаашид хүлээж болохгүй. Өнөөгийн олон улсын нөхцөл байдалд бид үүнийг цаашид тэсвэрлэж байж чадашгүй. Дайн нөмрөн айсуй. Троцкий фашизмын хамсаатан болчихлоо. Троцкийчууд зүүний хөдөлгөөнд шургалан орж, түүнийг түйвээн бусниулж, тэгснээрээ дэвшилт хүчний Зөвлөлтөд үзүүлж чадах байсан тусламжийг сулруулж байна. IV Интернационалд цохилт өгөх хэрэгтэй. Яаж? Толгойгүй болгож.

Сталин Судоплатовын өмнө зогтусч, айхтар өрөмдөн хараад,

– Троцкийг нэг жилийн дотор устгасан байх ёстой гэж ширүүн хэлэв. – Таныг энэ ажлыг чадна гэж найдаж байна. Мексик рүү яв. Танд бүх нөхцлийг бүрдүүлж өгнө, шаардлагатай тусламжийг үзүүлнэ.

Судоплатов хариу хэлэхээр босоход, Сталин,

– Суу! гэж тушаалаа.

Судоплатов сандал руу лагхийн суусан боловч, сууж байхдаа ч номхон зогсож байгаа мэт ийн илтгэв:

– Нөхөр Сталин! Бид таны заалтыг биелүүлэхийн тулд бүхнийг хийх болно. Гэхдээ би Мексик рүү явах нь зохисгүй: би испани хэлгүй учраас өөр рүүгээ дэмий анхаарал татна.

– Тэгвэл Эйтингон?

– Бид чухам тэгж шийдсэн байгаа, нөхөр Сталин. Газар дээр нь ажилбарыг нөхөр Эйтингон толгойлно.

– Тэр чинь ямар шуухан хүн билээ?

– Дөчтэй. Туршлагатай тагнуул, найдвартай, овсгоотой, тууштай. Намын 1919 оны гишүүн. Цэргийн академид суралцсан, нөхөр Зержинскийтэй ажиллаж байсан. Испанид өөрийгөө маш сайн харуулсан. Англи, герман, франц, испани хэлийг чөлөөтэй эзэмшсэн.

– Ажилбарын ямар төлөвлөгөө байна?

– Хэд хэдэн төлөвлөгөө боловсруулсан байгаа. Газар дээр нь тодорхой шийднэ. Тэдгээр хувилбарын нийтлэг зүйл юу вэ гэвэл, ажилбарыг Зөвлөлтөд бэлтгэл хийсэн, Испанид байлдаж байсан коммунистууд хэрэгжүүлнэ.

– За тийм байж, ажиллацгаа! Хөрөнгө хайрлах хэрэггүй хэмээн Сталин Судоплатов руу дахин айхгар харснаа, – Троцкийг устгах явдал манай намын Төв Хорооны даалгавар гэдгийг бодоорой. Амжилт хүсье, баяртай гээд гараа өгөв.

Сталин, Берия хоёр үлдэв.

– Танаар юу байна? гэж Сталин асуулаа. Берия түүний өмнө нэг хуудас цаас тавив. Энэ нь Литвинов нэг хувийн ярианы үеэр нам, засгийн удирдлагын гадаад улс төрийн үйл ажлын талаар буруушаасан юм ярьсан тухай Гадаад хэргийн ардын комиссариатын ажилтны мэдээлэл ажээ.

Сталин Литвиновын занг мэдэхийн хувьд түүнийг тэгж чадах хүн гэж үзэж байв. Ер нь ч германуудтай илүү өргөн хүрээтэй яриа хэлэлцээ рүү шилжих цаг боллоо. Литвинов энэ ажилд таарахгүй.

тэрээр, нэг удаа Литвинов түүнийг Лондонд боомтын согтуу ажилчдаас хамгаалсныг, мэдээж, мартаагүй байгаа. Өнгөрсөн гучин жилийн хугацаанд Литвинов энэ тухай хэнд ч хэлээгүйг, мэдээж, үнэлэж байгаа. Гэхдээ аливаа талархалд хэмжээ хязгаар гэж бий. Улсын удирдагчид хувийн найз байхгүй, байдаг ч үгүй, түүнд гагцхүү түүний хийж байгаа аугаа их үйл хэрэг л бий. Бас хүмүүс ч энэ үйл хэргээ хийхэд нь түүнд тус бологч, саад бологч гэж хуваагдана. Нөхөр Литвинов үүнийг ойлгохгүй байгаа нь харамсалтай. Ингэж ойлгоогүйгээсээ болоод олон хүн амь насаа алдсан даа. Гэхдээ Литвиновын амь насыг түйвээх хэрэггүй, Литвинов дахиад хэрэг болж мэднэ.

Сталин мэдээллийн булан дээр “Хэрэгт нь авах” гэж бичив. Цаасыг Берия-д буцааж өгөнгөө,

– Литвиновг одоохондоо гар хүрч болохгүй. Гэхдээ би түүний үг болгоныг мэдэж байх ёстой. Тэр үгийг хаана хэлсэн байх нь хамаагүй.

Тавдугаар сарын 3-нд Литвиновыг гадаад хэргийн ардын комиссарын албан тушаалаас халж, оронд Молотовыг тавьжээ. Молотов Совнаркомын дарга хэвээрээ үлдсэн байна. Литвиновыг

халж, Молотовыг тавих шөнийн ёслол дээр Маленков, Берия нар байлцав. Берия байлцсан нь санаандгүй хэрэг биш байж. 1939 оны зун гэхэд Литвиновын таван орлогч, 48 элчин сайд, Гадаад хэргийн ардын комиссариатын 140 ажилтан, хилийн чанадахь Зөвлөлтийн элчин сайдын яамдын олонх албан хаагчдыг залхаан цээрлүүлжээ. Сталинч шинэ гадаад бодлогыг шинэ хүмүүс хэрэгжүүлэх учиртай.

Хичээл эхэлтэл хоёр цаг байсан учир Глеб, Саша хоёр шуудангаар оров. Өөрөө хүлээн авах захиаг тэндээс авна. Глебт эгч авгай нь захиа бичих нь ховор, харин Сашад ээжээс нь захиа ирсэн байв. Тайван захиа. Саша хэдэн удаа ээждээ мөнгө гуйвуулсан, ээж нь түүнийг мөнгө нь хүрэхгүй зовж байгаа гэж бодоод тухай бүр дургүйцэн зэмлэвч, Саша бүх юм дажгүй байна, байр нь арай сайн, цалин нь арай илүү учраас Уфад үлдэхээр шийдсэн гэж учирласныг яваандаа эрхбиш ойлгож эхэлжээ.

Саша цонхны дэргэд зогсоод ээжийнхээ захиаг уншив. Глеб лангууны арын бүсгүйчүүдтэй энэ тэрийг хөөрлөө, ноднин тэдний бүлэгт хичээллэж байсан дандаа танил хүүхнүүд. Саша захиагаа халааслаад танхим руу хартал, өөрөө хүлээн авдаг цонх руу хар пальтотой, бараан саарал дугуй малгайтай өндөр хүүхэн очиж паспортоо сарвайв. Зурсхийсэн царайд нь ямар нэг танил мэт юм харагдсан тул Саша түүнээс хараа салгасангүй. Холбооны бүсгүй захиа алга гэж хэлэхэд, лангуу налж байсан сайхь хүүхэн эргэлээ. Ээ бурхан минь, Лена Будягина!

– Лена!

Гонзгойдуу цайвар царай, яльгүй доровгор уруул энэ тэр нь хэвээрээ, хэзээний хөөрхөн янзаараа хэрнээ нүд нь ядрангуй харцтай, шинэлэг, ширүүлэг гэлтэй аж.

тэрээр мань эр рүү духайсхийн харав. Хүүхэд ахуйгаас танил энэ харц түүнд тэдний ангийг, тэдний сургуулийг, тэдний эв найртай найз нарыг санагдуулж, Арбатаар ханхлаад явчих шиг болов.

– Сайн байна уу, Саша, чамайг хараад баярлаж байна гэж тайван өгүүлэв. Ингэж санаандгүй уулзсандаа гайхаж байгаа янз алга. Уул нь таван жил уулзаагүй шүү дээ. Өөрийг нь Уфад байгаа гэж мэдэж байгаа юм болов уу?

Глеб хүрээд ирлээ. Цагаан шүдээ яралзуулан Лена руу инээв. Саша тэднийг танилцуулав: Лена, манай ангийн хүүхэд, бага болоод идэр насны минь найз. Энэ бол Глеб, дотнын анд нөхөр.

Тэд гудамжаар гурвуулаа алхлаа. Саша түүнээс Москвагийн тухай, анд нөхдийнхөө тухай асууж, Уфад ирээд удаж байгаа эсэхийг нь лавлав. Лена товчхон хариулж байв: Уфад хэдийн хагас жил болчихлоо. Найз нар уу? Макс армид байгаа, Нина хүнтэй суугаад нэг тийшээ яваад өгсөн, Вадим Москвад юм шиг байна лээ. Биеэ барьсхийж байна, нэг ч овог хэлэхгүй гагцхүү нэр хэлж байна, Шарокийн тухай юу ч дуугарсангүй, уул нь хүүхдийнх нь эцэг шүү дээ. Нинагийн хаашаа явсан тухай нэг ч үг хэлсэнгүй, гэтэл Алс Дорнод руу, Макс дээр очсоныг Саша ээжээсээ дуулсан билээ. Бас Макс эдүгээ Зөвлөлт Холбоот Улсын баатар, энэ тухай сонинд гарсан, гэтэл Лена чухам ямар Максын тухай ярьж байгаагаа тодруулсангүй, эцэг эхийнхээ тухай, бас яагаад Уфад ирчихсэн тухайгаа юу ч дурссангүй.

Тэр гурав автобусны буудал дээр ирэв.

– Чи алинд суух вэ? гэж Саша асуув.

Лена гурван чиглэл бичээтэй байгаа пайз руу харлаа... Тэгээд азнаснаа,

– Ялгаагүй, аль нь ч болно гэж хариулав.

Гурван чиглэл өөр өөр тийшээ юм чинь түүнд аль нь ч таарна гэж байх ёсгүй.

– Чи хаягаа өгөхгүй юм уу, би танайхаар очъё гэж Саша хэлэв.

– Үгүй ээ, би хол суудаг юм. Би танайхаар очиж болно, эсвэл хоёулаа нэг газар уулзаж болох юм, хавар болчихсон, дулаахан байна шүү дээ.

– За тэгье. Миний хаягийг бичээд ав.

– Би тогтоочихно.

мань хүн хаягаа хэлж, өдөр, цагаа тохирцгоолоо. Лена ирсэн автобусанд суув.

– Гоё хүүхэн, баахан болгоомжтой юм гэж Глеб өгүүлэв.

– Сургуулийн тэргүүн гоё охин байсан юм. Болгоомжтой гэв үү? Одоо болгоомжгүй хэн байна? Намайг таван жилийн өмнө баривчилж цөлснийг мэдэж байгаа, тэгтэл сая гэнэт Уфад харлаа л даа. Би одоо ямар байгааг тэр мэдэхгүй.

тэрээр Глебт бүх юмаа итгэдэг, гэхдээ өөрийнхөө юмыг, гэтэл энэ бол хүний явдал. Лена өөр овогтой болсон байж болно, хүнтэй суусан байж болно шүү дээ. Одоохондоо түүний тухай юу ч ярихгүй байя.

– Ялдам минь, тэр чинь надаас болж л болгоожлоод байлаа шүү дээ. Тэр нь ч зөв: би хэн юм бэ, магадгүй, чи бид хоёр хоёулаа Сибириэс оргосон ч юм бил үү? Тааралдсан автобусанд суугаад чи бид хоёроос зугтчихлаа. Буруушааж байгаа юм биш, харин ч сайшааж байна. Танай сургуулийнхан цөмөөрөө чам шиг дүнхүү болж өсөөгүй юм байна.

– Тэгвэл л болох нь тэр, алив сонин харцгаая.

– Юуг нь харах вэ дээ, их хурал, их хурал гэхээс өөр юу байгаа аж.

Гэвч Сашагийн хамт сонингуудын самбарын хажууд зогслоо.

Бүх сонин намын XVIII их хурлын тухай тайлан мэдээгээр дүүрээд хэд ч хонож байна даа. Яг л нэг юм, яг л нэг юм... Илтгэл, хэлсэн үг, баяр хүргэсэн мэндчилгээ, нөхөр Сталинд өргөсөн ерөөл, нижигнэсэн алга ташилт.

Тэгтэл зохиолч Шолоховын хэлсэн үг байж байна. Саша түүнийг уншлаа. Тэгээд Глебт,

– Алив, энийг хар даа... гэв.

Глеб уншиж эхлэв:

– “...Зөвлөлтийн утгазохиол дайснаас ангижирснаар илүү эрүүл, илүү бат бөх боллоо... Бид тагнуулаас, фашистын туршуулаас, зүсэн бүрийн дайснаас ангижирлаа, гэхдээ энэ бүх новш бол чухамдаа хүн биш байсан юм... Энэ бол зөвлөлтийн утгазохиолын цэцэглэж байгаа амьд эд эсийг хөхөн шигдсэн шимэгчид юм... Манай зохиолчдын хүрээлэл цэвэршсэнээр гагцхүү хожлоо...” Үгүй ээ, уншиж чадашгүй нь. Дотор муухайрч байна. Явья гэж Глеб унтууцав.

– Унш, улс орон маань баатруудаа мэдэж байх ёстой!

– “...Бид баярлаж баясахдаа ч, гутарч гунихдаа ч сэтгэлдээ түүн рүү, манай амьдралыг цогцлон бүтээгч рүү дандаа ханддаг, тэгж заншсан, цаашид ч тийм байх болно, нөхөд минь. Нөхөр Сталин үнэнхүү хүнлэг даруу зангийнхаа хажуугаар бид бүхэн хайр хүндэтгэл, үнэнч сэтгэлээ уудлан илэрхийлж байгааг тэвчих ёстой (алга ташилт), яагаад гэвэл түүний удирдлагын дор ажиллаж амьдарч байгаа манайд төдийгүй бүх хөдөлмөрчин ард түмний хүн төрөлхтний гэрэлт ирээдүйд найдах хамаг найдвар түүний нэртэй холбоотой (Алга ташилт.)” Хөөе, би энэ бүхнийг уншиж яах юм бэ? Явцгаая! гэж Глеб дахин бухимдав.

– За яахав, явцгаая. Юу гэхэв?

– Барлаг!

– Гэхдээ “Дөлгөөн Дон”-ыг бичсэн шүү дээ, аугаа роман.

– Хориод онд түүний зохиосон гэдэгт эргэлзэж, бүр тусгай комисс хүртэл байгуулж байсан.

– Би тэр тухай ямар нэг юм сонссон.

– Надад Акимов ярьсан юм. Зохиогч нь цагаантны нэг офицер байсан. Гэвч тийм юмыг хүлээн зөвшөөрч чадах байсан уу?! Юу гэсэн үг вэ, ялдам минь?! Тэгтэл ард түмнээс гарсан, тосгоны, өөрийн хүн хажууд байж байна. Харин “Дөлгөөн Дон” суут роман юм бол зохиогч нь барлаг байж таарахгүй. Чиний хайрт Пушкины хэлсэнчлэн, ялдам минь, суу билэгтэн, хорон санаат хоёр бол нийцэшгүй зүйл.

– Тэр болгон суу билэгтэн айдсыг даван гарч чадахгүй. Ингэхэд Шолохов явж явж суу билэгтэн биш.

– Буудуулсан нөхдөө дэвсэлж байна, энэ юу вэ, айдас уу?

– Тийм, айдас.

– Үгүй шүү, ялдам минь, энэ бол манай Оросын барлагчлал. Барлаг эзнийхээ өмнө мөлхөнө, тэгвэл өөр нэг барлагийг эзний тушаалаар ташуураар ороолгосоор байгаад алчихна. Сэхээтэн та нарын амьсгал даран ярьж буй “аугаа их зөвлөлтийн ард түмэн” бол дээрээсээ доошоо хүртэл бүгдээрээ барлагууд.

– Сэхээтэн муу байна, ард түмэн муу байна гэнэ, чи өөрөө хэн юм бэ?

– Би, ялдам минь, бас адилхан барлаг, бүгдийн адил чихэн дээрээ тогтож байна. Чамд

өөрийнхөө нүдээр үзсэн юмыг ярьж өгье. Тэгэх үү?

Саша инээд алдав.

– Тэг л дээ. Чамд бүх тохиолдлоор ямар нэг түүх байдаг юм чинь.

– Чи сонс, аан гэж бай. Хорин ес бил үү, гучин онд байх, надад нэг хайрт байв аа, сайн охин, хөдөөгийн багш. Би тэрүүн дээр байсхийгээд очно, бид хоёрын эцгийн нэр ижил: би Васильевич, тэр Васильевна учраас намайг хүнд ахыгаа гэнэ. Бид хоёр шөнө нь, мэдээж, орон дээр холбирч өгнө, тэр тухайд бид чадамгай, өдөр нь би ой руу явчихна, зургийнхаа самбарыг бариад. Хөдөөний тийм нэгэн диваажин. Тариачид надад муугүй, нигүүлсэнгүй хандана, ажил хийдэг хүн хойно, зургийн самбар барьсан хотын хүнийг, зайлуул, “хүн гуай тэнэгтэж байна” гэх маягтай, бүхэлдээ дажгүй, сайн санаагаар хандана. Нэг удаа Клавочка бид хоёр шөнийнхөө ажилд цуцаад унтаж байсан чинь гадаа шуугиан гарахыг би сонслоо. Юу гээч юм бол? Тэр маань босч цонх руу очоод, хөшгөө ярснаа: “Голодухиныхны хөрөнгийг хурааж байна” гэж байна. Ингэхэд тэндхийхэн бүгд Голодухин, тосгон нь хуучин Голодухино нэртэй байсан, хожим, мэдээж, нэрийг нь өнөөгийн маягаар өөрчилж, “Империализмын аянга” гэх болсон юм.

– Битгий зал, бага шиг залаарай!

– Андгайлъя. Гуйлгачин хамтрал, гэхдээ яг тийм нэртэй: “Империализмын аянга”, тийм сүрдэм нэр.

– Онигоо!

– Гол нь энэ биш. Хамаг учир нь тосгоныхон бүгдээрээ Голодухин гэдэг ижил овогтой, бүгдээрээ хол, ойрын хамаатан. Тэгтэл аль нэг Голодухины хөрөнгийг хурааж байгаа юм байж. Би мэдээж өмдөө бушуухан өмслөө, тийм үзвэрийг харах хэрэгтэй. Гэтэл Клавка: “Явж болохгүй, тэнд сэргийлэхийнхэн, элдэв бүрэн эрхтүүд энэ тэр байна, чи эндхийнх биш юм чинь чамайг хоргооно, хэн юм бэ гээд бичиг баримт нэхнэ, тэгэх юм бол манайхан: Клавдия Васильевна багшийнд ирдэг, хонож өнждөг хүн гээд хэлчихнэ, би тэгүүлмээргүй байна. Эндээс хар, бүх юм ил байна, алив ийшээ зогс” гэж байна.

түүний хэлсэн газар зогсоод харсан чинь, нэг модон байшингийн хажууд хоёр тэрэг байна, цагдаа нар байшингаас авгай хүүхнүүд, хүүхэд хөгшдийг гаргаж байна, цаадуул нь эсэргүүцвэл хуулийн зүйл анги наачихна гэж мэдэх учраас эсэргүүцэхгүй юм, авгай нар боосон муусайн новшоо тэргэн дээр шидэлж байна, нэг явж чадахгүй хариугүй хатингар эмгэнийг цагдаа өргөж гаргаад тэргэн дээр хаячихлаа, нэг хөхүүл хүүхэд, бусад нь жаахан амьтад орилж чарлаад сүйд, ер нь нүд дальдрам, аймшигтай зураг, зүв зүгээр байгаа хүмүүсийг төрөлх нутгаас нь хөөж, идээшсэн оромжийг нь цөлмөн хоосолж, Сибирь рүү явуулж байна, чухамдаа бол үхэл рүү явуулж байгаа хэрэг.

Глеб зөндөөн удаан чимээгүй алхав.

– Гэхдээ, ялдам минь, гол юм нь өөр зүйл. Харчуул, авгай нар дэргэд нь чимээгүй зогсоод

байна, хүүхдүүд хүртэл хөшчихөж. Тэд нар цөмөөрөө Голодухин, хөрөнгөө хураалгасан айлын хамаатнууд, нэг насаараа хамт аж төрцгөөсөн улс. Тэгээд тэдний нүүрэн дээр ийм харгис явдал болж байна, хийж байгаа хүмүүс нь пиджактай нэг муу новшийн бүрэн эрхт, хоёр доожоогүй цагдаа. Муухай харсан бадриун чийрэг харчуул, мөн тиймэрхүү авгай нар зогсож байхыг хараад, тэдний царайд ямар бэлэн байдал байгааг хараад тэднийг одоо энэ муусайн руу дайрч, зэвсгийг нь булааж аваад, тэргэн дээр хаяж морьдоо ороолгон, тосгоноосоо хөөж явуулна даа гэж бодлоо. Тэгээд тэр мөчийг хүлээлээ. Гэтэл байдаггүй шүү... Цагдаа тэр гэр бүлийг хуу гаргаж тэргэнд суулгахад, эмс авгай нь үглэж дуулж, хүүхэд шуухад уйлаан майлаан боллоо, нөгөө хоёр цагдаа морьдыг ташуурдаад яваад өгөх нь тэр... Яг тэгсэн чинь үлдсэн бөөн улс дайрлаа шүү, араас нь, нөгөөдүүлийгээ аврах гэж биш, гай зовлонгоос салгах гэж биш, цаад зол муутгнууд нь авч явж чадалгүй үлдээсэн юмыг нь олзолж авах гэж байшин руу нь дайрч байгаа юм. Тэгээд манайхны нөгөө сайхан сэтгэлт, өрөвч авгай нар чинь нэг нь ваар, нөгөө нь таваг, гуравдахь пийшингийн хаалт энэ тэр барьчихсан, хүүхдүүдээ дагуулчихсан, сэтгэл хангалуун, баяртай амьтад тосгоны зөвлөлийн дарга ирж энэ тонуулж шившиг болсон байшинг битүүмжилж амжаагүй дээр гэр рүүгээ яаран алхацгааж байна. Би тэгэхэд арван ес-хорь эргэм настай байсан. Манай ард түмэн, тариачин эрээс авахуулаад саяны энэ зохиолч Шолохов хүртэл, жирийн авгайгаас авахуулаад өөрийгөө тушаах л юм бол тагнуул, хорлон сүйтгэгч гэж хүлээн зөвшөөрдөг Улс төрийн товчооны гишүүн хүртэл бүгд барлаг гэдгийг би тэр мөчид ойлгосон юм. Тэгэхээр элдэв Достоевский мэтийн философичдын онцгой сэтгэл, онцгой үүрэг, онцгой зориулга энэ тэрийн тухай бичсэн бүх юм бол бүгдээрээ дэмий балай зүйл! Бас Тютчевийн: “Оросыг ухаанаар эс ойлгоно... Орос онцгой араншинтай” энэ тэр гэдэг бол, ялдам минь, яруу найргийн хий цэцэрхэл, яруу найргийн уран сэтгэмж.

– Тосгон тэр чигээрээ үүнд оролцсон уу? гэж Саша асуув.

– Мэдээж бүгдээрээ биш л дээ, тэглээ гээд юу өөрчлөгдөх билээ?

– Их юм өөрчлөгдөнө. Хэдэн тонуулчид хараахан ард түмэн биш. Өөрийн гэх балмадууд хаана ч бий.

– Яагаад “сайн хүмүүс” хөршөө хамгаалах гэж ирсэнгүй вэ?

– Тэгвэл чи ирсэн үү? Чи хамгаалсан уу?

– Ялдам минь, би ч бас тийм л барлаг.

– Тэгвэл бусдаас битгий шаардаж бай! Ялангуяа бүх насаараа дарлуулж, дөрлүүлж яваа тариачнаас шаардах хэрэггүй. Тэдэнд дээрэлхэгчдээс бид ч юм байцаахгүй, тэр бол осолтой, гэтэл бид аж төрөхийг хүсч байна, бүжиглэхийг хүсч байна, балгахыг, зуушаар даруулахыг хүсч байна.

Тэр хоёр рестораны хажуугаар явж байсан учир Глеб,

– Зууш гэснээс ийшээ орьё гэв.

– Ганц цагийн өмнө юм идэх чинь билээ. Зуу татмаар байна гээд л шуудхан хэлчихээч.

Глеб инээд алдан,

– Тийм шүү, ялдам минь, хичээлийн өмнө зуу татчихмаар байна гэв.

Саша цагаа харснаа,

– Амжихгүй ээ. Хичээлээ хийчихээд орж балгацгаая гэв.

– Чинийхээр болог, орой руу шилжүүлье. Харин би чамд ганц юм хэлье. Чи намайг зүхэж байна, гэтэл чи өөрөө хэн юм бэ?

– Би бол чи л гэсэн үг. Гэхдээ би ямар ч байдаг бай, хөөрхий болсон, хууртсан хүмүүс рүү муу юм чихэхгүй. Би тэднийг биш өөрийгөө үзэн ядаж байгаа.

Глеб нэг хэсэг чимээгүй явснаа,

– Би герман гаралтай ч юм уу, эсвэл өөр аль нэг өөр ястан учраас ард түмнийхээ тухай ингэж ярьж байгаа юм биш. Үгүй шүү, ялдам минь, би бол цэвэр үүлдрийн орос хүн, одоо энүүгээрээ бахархахыг зөвшөөрч байгаа, одоо эх оронч үзэл моодонд байгаа. “Александр Невский”, “Минин, Пожарский хоёр”, “Анхдугаар Петр” энэ тэр гэсэн киног яах гэж авч байна? Эх оронч үзэл төлөвшүүлэх гэж, орос эх оронч үзэл төлөвшүүлэх гэж авч байна, ялдам минь. Би чамд тэр ч байтугай юм хэлнэ, зөвхөн чамд: би бол эртний сурвалжит удам дамжсан орос язгууртан, миний өвөг дээдэс Догшин Иваны үед Казань, Астраханийг эзэлж байсан, бас Суворовтой Альпын нуруу давж гавьяа байгуулж явсан, тэдний дунд хотын дарга нар, декабристууд, газрын эзэд, ардын зоригийнхон гээд элдвийн хүмүүс байсан, харин ганц ч герман байгаагүй. Гэхдээ манай удам судрын цус шингэрсэн, худалдаачидтай ураг барилдсан, сэхээтэн болцгоосон, их сургууль төгсөцгөөсөн, профессорууд ч, зураачид ч байсан, тийм учраас миний язгууртан гарлыг бурханы авралаар өдий хүртэл шиншилж мэдсэн хүн нэг ч байхгүй. Харин би тайж язгуураа юу ч биш гэж үздэг юм шүү, ялдам минь...

Тэр хоёр Хөдөлмөрийн ордон дээр ирлээ. Глеб хаалганы бариулаас барьж авснаа онгойлголгүй,

– Чиний энэ сургуулийн найз Лена чинь аятайхан амьтан байна шүү гэж гэнэт өгүүлэв.

– Чи иймэрхүү тохиолоор мундаг дагина гэдэг биз дээ хэмээн Саша жуумалзахад,

– Үгүй ээ, энэ удаад арай дорвилог нэг юм байна гэж Глеб бодлогоцрон хариулав.

Молотов бодохдоо удаан, цаг алдаж мэднэ, гэтэл удаашруулж болохгүй. Гитлер Польшийг намар зам харгуй явж болохоо байхаас өмнө эзлэх санаатай байна, тэгэхээр Зөвлөлттэй барих харилцаагаа зохицуулах ёстой. Одоо ТЭР ӨӨРӨӨ биш, Гитлер л зохицох арга зам хайж, буулт хийх болно. тэрээр Гитлерийг доромж байдалд албадан оруулахгүй, хүн доромжлуулснаа мартдаггүй, боломж гарангуут өсөө авдаг. Гэхдээ ӨӨРӨӨ Гитлерийн нүүдлийг маш сайн ойлгож байгаагаа түүнд харуулна. Энэ бол хоёр маш хүчирхэг гүрний удирдагч нарын хэлэлцээ, сонирхол нь таарч байгаа хүмүүсийн хэлэлцээ байх болно.

ЗСБНХУ, Герман хоёр Англи, Францыг сөрөн зогсоно. тэрээр энэ үзэл баримтлалыг арван жилийн өмнө хэлж байсан, одоо тэр нь бүрэн нотлогдлоо. Гитлер Польшийг нэг хоёрхон сард бут ниргэнэ. Харин Англи, Франц хоёр Гитлертэй нэг дайтаад эхлэх юм бол өд мөддөө дуусахгүй. Дэлхийн нэгдүгээр дайн дөрвөн жил үргэлжилсэн, энэ дайн бол түүнээс ч урт үргэлжлэнэ. Тэд хоорондоо тэмцэж байгаад өөрсдийгөө туйлдуулна, харин ЗСБНХУ энэ хооронд нь хамгийн аюултай цэргийн хүч болж, тэрээр дайнд тамирдсан Европт өөрийнхөө болзлыг тулгах болно.

түүний заалт ёсоор Берлин дэх Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгчийн газрын зөвлөх Астахов Германы гадаад хэргийн яаманд очиж, Зөвлөлт Холбоот Улс, Герман хоёрт гадаад бодлогын асуудлаар зөрчил байхгүй гэсэн утга бүхий зүйл ярилцсан байна.

Долоо хоногийн дараа Германы элчин сайд Шуленбург Молотовт: “Герман, ЗСБНХУ хоёрын харилцааг эрүүлжүүлэх цаг болжээ. Польшийн асуудлыг шийдэхэд Оросын сонирхлыг бодолцоно. Англи ЗСБНХУ-д тусламж үзүүлж чадахгүй, үзүүлэхийг ч хүсэхгүй байна, Англи ЗСБНХУ-аар албаар могой бариулж өөрөө хожно” гэж мэдэгджээ. Сайн мэдэгдэл. Гэхдээ Берлинд бол Астаховт: “Хэрэв ЗСБНХУ Германы сөргөлдөгчдийн талд орохыг хүсч байгаа бол, Германы засгийн газар сөргөлдөгч болоход бэлэн байна” гэж хэлжээ.

Энэ бол айж сүрдэм сонсдож байна. Ийм аясаар ярихыг тэрээр хэрхэвч тэвчихгүй. Гитлер цухалдаж байна, Польш руу довтлох хүртэл гурван сар үлдсэн, гэхдээ биеэ барьж байх хэрэгтэй. Гитлер бол хийрхэгч. Гинденбург түүнийг Германы канцлерийн хувьд нь тангараг өргүүлсний дараа уйлчихсан. Уяхан ч герман бол доо. Германы 1918 оны арван нэгдүгээр сарын хувьсгалын тухай сонсоод бас уйлсан гэж “Майн Кампф”-даа бичсэн байна. Австрийг Германд нэгтгэсний дараа Венад ирэхдээ, эх орондоо эргэж ирсэндээ сэтгэл догдолж уйлсан. Мэдээж, хуурамч нулимс. Архи уухгүй, тамхи татахгүй, цагаан хоолтон. Мянга мянган хүнийг гудиггүй мэс рүү илгээнэ. Тогтворгүй зантай хүн. Гэхдээ ТҮҮНТЭЙ бол үгээ цэнэж ярьж байх хэрэгтэй болно.

Германтай улс төрийн яриа хэлэлцээг зогсоож, юуны өмнө худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурахыг шаардаж байхыг Сталин Молотовт тушаав. Молотов бол ийм тактикийн эзэн. Арга саам хийх, хойш нь чангаа бол түүний ганц хужир, түүний араншин. Улс төрийн хэлэлцээг үргэлжлүүлэх гэж зургаа, долдугаар сар хийсэн Германы бүх оролдлого худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурахыг шаардсан Молотовын хүйтэн хянуур байр суурийг мөргөж зоогдчихоод байв. Тэгээд дөнгөж долдугаар сарын 22-нд зөвлөлтийн хэвлэл: “Зөвлөлт,

Германы худалдаа, зээлийн тухай хэлэлцээ сэргэв” гэсэн мэдээ нийтлэв.

Эцсийн эцэст, тав хоногийн дараа, Астахов Германы тэргүүлэх дипломат Шнуре-тэй ярилцсан зүйлийнхээ тайланг ирүүлэв. Шнуре фюрерийн нэрийн өмнөөс: “Германы бодлого Английн эсрэг чиглэж байгаа. Энэ бол шийдвэрлэх хүчин зүйл. Манайх Зөвлөлт Холбоот Улсад заналхийлэх тухай яриа ч байх ёсгүй. Ертөнцийг үзэх үзлийн ялгааг эс харгалзан, Герман, Итали болон ЗХУ-ын үзэл сурталд нэг нийтлэг зүйл байна: капиталист ардчилалыг сөрөн зогсох явдал. Англи Орост юу санал болгож чадах вэ? Оросын санаанд тохирох нэг ч зорилгыг санал болгож чадахгүй. Бид юу санал болгож чадах вэ? Бие биеийнхээ сонирхлыг харилцан ойлгохыг санал болгоно, үүнээс аль ч тал нь хожоо олно.

түүний тактик зөв болж таарав. түүнийг Англитай тохирчих вий гэж Гитлер үнэхээр санаа зовж байгаа. Гэхдээ тэр тодорхой юу санал болгож байна?

Сталин Астаховт явуулах цахилгааныг дуудаж бичүүлэв:

“Хэрэв германууд үнэн санаанаасаа баримжаагаа өөрчилж, ЗСБНХУ–тай харилцаагаа сайжруулахыг үнэхээр хүсч байгаа бол тэр сайжралтыг тэд яг хэрхэн төсөөлж байгаагаа бидэнд заавал хэлэх ёстой. Энэ тухайн ажил тэр чигээрээ германуудаас хамаарна”.

Цахилгаанд Молотов гарын үсэг зурна. Гэхдээ энэ бол дипломатын цахилгаан биш. түүний бичлэг. Гитлер үүнийг ойлгоно.

Гитлер ойлгосон, Гитлер яарч байна. Ийм хариу иржээ:

“Балтийн тэнгисээс Хар тэнгис хүртэл асуудал гарахгүй. Балтийн тэнгист тус хоёр улсад хүрэлцээтэй зай бий. Германууд Польштой асуудлаа долоо хоногийн хугацаанд зохицуулна. Хэрэв оросууд хүсэх юм бол Герман тэдэнтэй Польшийн асуудлаар хэлэлцээр байгуулна”.

Наймдугаар сарын долоонд түүний ширээн дээр тагнуулын мэдээ тавилаа: “Наймдугаар сарын 20-ноос эхлэн Польшийн эсрэг дайны ажиллагаа эхэлснийг харгалзвал зохино”.

Маргааш нь Ворошилов яаралтай юм илтгэж ирэв: Монголд, Халх голын районд, япончууд гол дайралт хийхийн тулд генерал Камацубарагийн удирдлагын дор цэрэг төвлөрүүлээд байна.

Хоёр фронтод дайн хийх аюулаас тэрээр хамгийн их айж байсан бөгөөд тэр аюул бодитой болж байна.

– Халх голын тухайд хэрэг явдал өрнөхийн хэрээр илтгэж бай гэж Сталин хэлээд, – Англи, Францын цэргийн төлөөлөгчидтэй хийх хэлэлцээ юу болж байна? гэж асуув.

– Хэлэлцээ маргааш эхлэнэ. Польш манай цэргийг нутаг дэвсгэрээрээ гаргахаас татгалзаж байгаа нь гол бэрхшээл болж байна. Манай тусламжийг аваач гэж бид Польшоос өвдөг сөгдөн гуйж байлтай нь биш дээ.

– Герман Польшийг эзэлж авснаар манай хил рүү дөхөөд ирнэ, ингэж ойртох нь Гитлерийг

ЗСБНХУ-ын эсрэг түрэмгийлэл үйлдэх зам руу түлхэнэ гэж Англи, Франц хоёр тооцоолж байна. Тэд нар Гитлер манай руу биш, тэдэн рүү дайрч чадна гэдгийг эрэгцүүлж бодохгүй байна. Тэдний цэргийн төлөөлөгчидтэй чиний хийх хэлэлцээ юу өгөхийг харья. Тэд ч ухаарах нь юу л бол.

Сталин гарынхаа ирмэгээр ширээ түншин, сүрхий гүрж аялгатай ярьж байв.

Ворошилов эвгүй хөдөлж нөхөр Сталины уурыг хүргэхээсээ айгаад чив чимээгүй сууна.

– Хэлэлцээгээ эхэл, байр сууриа хатуу барь, тэгээд харья хэмээн Сталин төгсгөв.

Удалгүй дуудлага ирлээ. Цагдаагийн газар Варяд үнэмлэх саадгүй өгөв: Максын Зөвлөлтийн баатар цол нөлөөлж буй хэрэг.

Хабаровскт яльгүй төвөг учрав. Үнэмлэх шалгаж байсан залуухан дэслэгч:

– Хүүхэд яагаад таны паспортонд бичигдээгүй юм? гэж асуув.

– Энэ маань эцгийнхээ паспортонд бичигдсэн юм.

– Танд гэр бүл бүртгэсэн тэмдэглэл алга байна.

– Бид бүртгүүлээгүй юм.

– Тэгвэл хүүхдийн төрсний гэрчилгээ хаа байна?

– Айлд зочилж явахдаа хүртэл хүүхдийн гэрчилгээ авч явах юм гэж үү?! Нөхөр дэслэгч ээ! Үнэмлэх олгохдоо миний бүх бичиг баримтыг хөндлөн гулдгүй шалгасан, та чинь Москвад итгэхгүй байгаа хэрэг үү?

– Журам бүх иргэдийн хувьд адилхан, дараачийн удаа битгий зөрчөөрэй! гэснээ Варяг сонжих мэт хараад үнэмлэх дээр нь тамга дарав.

Макс Зөвлөлт Холбоот Улсын баатрын хувьд одоо улс орон даяар алдартай, албан тушаал, цол хэргэм ахьсан хэдий ч тэдний гэрт баяр хөөр, амар тайван байдлын аль нь ч мэдэгдэхгүй байх ажээ. Нинагийн үс туг тугаараа бууралтчихаж, арай л эрт гэлтэй.

– Аав бас эрт буурал суусан, энэ бол удамшлынх.

– Зүгээр, харин ч чамд зохиж байна гэж Варя тал засав.

Макс, Нина хоёр нэг их юм ярихгүй байгаа ч гэсэн ялалт амжилтыг эс харгалзан Алс Дорнодод ч Москвагийнхтай адилхан юм болж байгааг Варя ойлгожээ. Сонин хэвлэлд яг л нөгөө хийрхэл, гучин долоон онд цэргийн бараг бүх удирдах бүрэлдэхүүнийг орон шоронд хийчихсэн, шинээр томилогдогсдыг нь энэ жил хийчихэж.

Нина энэ сэдвээр ярилцах дургүй, Варя харилцаагаа хурцатгаад яахав, Ванягийн учрыг олох хэрэгтэй гэж бодоод чимээгүй байлаа. Гэвч Нина эхлээд тэвчээр алдав. Урд өдөр нь Макс намын хурал дээр орой болтол саатаж, Варяг унтсан хойно ирээд, өглөө босоогүй байхад нь яваад өгчээ.

Өглөөний цайн дээр Нина ийн гомдоллов:

– Макс ийм хурлаас сэтгэлээр уначихаад ирэх юм. Байлдагч нарыг мэдээлэгчээр элсүүлж, дарга нарыг нь албадан ховлуулна. Нэг цэрэгт анхааруулга өглөө гэхэд нөгөөдөх нь тусгай төлөөлөгчид очоод шал дэмий юм донгосчихно, энэ дэмий юмных нь төлөө цэргийн шүүхээр

шүүлгэнэ.

Тэгээд ширээний араас босч, дахиад энэ тухай ярихаа больжээ. Мэдээж өрөвдмөөр, айдас хүйдэсний дунд амьдарч байна. Гэтэл одоо айдасгүй амьдарч байгаа хүн хэн билээ дээ?

Лена Будягинагийн тухай ярьсан зүйлийг Макс, Нина хоёр чимээгүй сонсчээ.

Гэтэл Нина Варятай хоёулхнаа үлдмэгц,

– Чамаас цахилгаан аваад, тэр хүүхдийг Саша та хоёрынх, тэгээд та хоёрт, эсвэл ганц чамд аюул нүүрлэчихэж, аврах хэрэгтэй гэж шийдсэн юм. Макс бид хоёр Сашаг дахиад баривчилсан байхыг үгүйсгээгүй, бас чамайг ч барихаар ирж мэднэ, тэр ч бүү хэл чамайг энд хүнтэй суулгах хэрэгтэй болох юм биш байгаа гэж бодоцгоож байлаа. Бид хоёр хормын зуур ч эргэлзэж байгаагүй: чи бол миний дүү, тэгээд Саша Макссын хувьд хэн гэдгийг чи мэднэ. Ингэхэд Саша юу болсон бэ?

– Хот дамжин хэсүүчилж яваа, хаа таарсан газраа жолооч хийж байгаа гэж Варя товчхон хариулав. Саша тэр хоёрын бүх юм ёсоор байгаа гэж Нина итгэж байгаа. Хойшид ч тэгж л бодож байг. Уул нь түүнийг Саша тэр хоёрын тухай яриад эхлэхээр зүрхийг нь зүсчих шиг болж байгаа л даа.

– Хөөрхий муу Саша, хэцүү юманд өртсөн гэж Нина санаа алдав. – Гэхдээ нөгөө талаас, аз нь дайрсан ч байж магадгүй. Хэрэв түүнийг одоо барьсан бол, мань хүн дэндүү биеэ даасан, зарчимч учраас одоо барих нь бол гарцаагүй, тэгсэн бол буудан л авах байсан.

– Тэр ч тийм л байх.

– Товчдоо, Саша та хоёрыг манайд хүүхдээ орхихоор шийдэж дээ гэж бид бодсон юм. Дахин хэлэхэд ямар ч эргэлзээ байгаагүй, гэтэл Лена, Шарок хоёрын хүү, Будягины зээ...

– Шарок хэрэг явдалд хамаагүй гэж бодож байна гэж Варя өчив.

– Тэрийг би зүгээр л далиманд хэлчихэж хэмээн Нина тодотгоод, – Харин Будягины зээ гэдэг бол! Хэрэв мэдчих юм бол Максимд ардын дайсанд тусалсан хэрэг тулгачихна, өөр юу наахыг чөтгөр л мэдэх байх, ухаж төнхөөд намайг мэдчихнэ, товчдоо сүйрэл гэсэн үг гэв.

– Чи айж байгаа юм уу?

– Айж байна. Нээрэн шүү. Гай газар дороос гэх шиг юм болчихлоо. Ийм бодолд дасах хэрэгтэй, бүх юмыг сайтар бодох хэрэгтэй. Энэ хүүхдийн тухай яг үнэн нь ийшээ ирэхгүй гэсэн баталгаа байна уу?

– Ирнэ гэсэн ном байхгүй! Эрүү шүүлт тулгасан ч Лена түүний хаана байгааг хэлэхгүй, та нар баларвал Ваня ч бас балрана гэдгийг ойлгож байгаа. Тэр хүүхдээ галт тэрэгний буудал дээр орхичихсон гэдэг тайлбар хэлэх ёстой, одоо хаа сайгүй тэгж хаяж байгаа юм чинь.

– Тэгвэл Софья Александровна мэдэж байгаа юу?

- Би түүнд, энэ бол миний найз хүүхний хүү, нөхрийг нь баривчилчихсан, өөрөө баригдана гэж айгаад Москвагаас зайлж одсон, тэгээд Алс Дорнодод байдаг хамаатныдаа хүүгээ хүргэж өгөөч гэж надаас гуйсан юм гэж хэлсэн.
- За яахав хэмээн Нина нэг их итгэлтэй бус санал нийлэв. – Одоо хоёр дахь асуудал. Хүүхдэд ямар ч бичиг баримт алга.
- Дүү чинь хүүтэйгээ чам дээр ирснийг хөршүүд чинь мэдэж байгаа. Би өдөр болгон Ванятай салхинд гарч байгааг бүгдээрээ харцгаасан. Танай энд найтаах төдийг ч андахгүй.
- Юу ч гэхэв, манайхны бүх харчуул чам руу нүд алдацгааж байгаа.
- Би энэ нэг өлзийтэй өдөр алга болчихно. Макс та хоёр...
- Варенька, тэрнийг Максим гэж бай л даа. Макс гэдэг чинь сургуульд байхын нэр. Орос биш дуудлага. Энд чинь өчүүхэн төдий ч гадаад авиаг маш сэжигтэй хүлээж авдаг юм.
- За мэдлээ. Максим та хоёр: үгүй, мөн дүү шүү, хүүхдээ хаячихаад алга болоод өгөх юм гээд мэл гайхсан дүр эсгэнэ биз. Намайг завхай зайдан, хормойн донтой, хаа ч хамаагүй тэнэж яваа гэхчилэн муулаад над руу чихэж болно.
- Тэр ч дэндэнэ ээ, ийм үг! хэмээн Нина ярвайв.
- Зүгээр, танай хорооны авхай нар бах нь ханан шовширч, өөрсдийнхөө зүгээс: нэг аальгүй юм энд шарваганаад, нүдээрээ сэртэндээд, ямар амьтан гэдэг шууд илэрхий байсан юм. Хөөрхий муу Нина Сергеевна, одоо энэ хаягдмал амьтантай энэ л зовно доо гээд давслаад өгнө.
- Чи мөн дураараа сэтгэнэ шүү хэмээн Нина инээмсэглэв. Инээмсэглэсэн бус инээхчээн аядсан хэрэг.
- Энэ бол уран сэтгэмж биш, бодит байдал. Миний тухай хэл амаа билүүдэцгээгээд байвал “хөөрхий хаягдмал баньдийг” мартана. Эцгийнх нь нэр овгийг ч мэдэхгүй юм, ялдамхан дүү маань ч хэний хүүхдийг төрүүлснээ бас мэдэхгүй гэх маягийн хэлээд, түүнийг Костин гээд бүртгүүлчих.
- Энэ сэдвээр дасгал хийхээ больж үз!
- Чамд л үндэслэл хаяж өгч байна. Харин зөвлөлтийн хүнийг, эх орны ирээдүйн хамгаалагчийг хүмүүжүүлэх тухайд бол юу хэлэхээ чи өөрөө мэднэ гэж бодож байна.
- Чи битгий ёгтлоод бай хэмээн Нина хөмсөг зангидав. – Чиний ингэдэг нас чинь аль хэзээ өнгөрсөн. Би ч гэсэн, далиманд хэлэхэд, жаахан өссөн.
- Гэхдээ Ваня Максын, өө уучлаарай, Максимын байдлыг төвөгтэй болгоно гэж ямар ч байсан үзэх юм бол би энэ хүүхдийг буцаагаад аваад явна.

– Тэгээд яахав?

– Ганц бие эх шиг өөрөө өсгөнө.

– За боль, битгий хүн айлгаад бай. Харзная. Бодъё. Максим бүгдий нь шийднэ.

Маргааш нь Нина хар үүрээр босч, Варягийн сэрэхийг хүлээв. Яриагаа шулуухан эхлэв:

– Чиний тайлбар миний санаанд буухгүй байна: “Хүүхдээ орхичихсон... Яваад өгсөн... Одоо түүнийг хаанаас хайхаа бид мэдэхгүй байна...” Энэ бол гоомой байна.

Варягийн үндэслэлийг шөнө Максимтай ярьсан байх нь. Варя Максыг хуучин янзаараа Нинагийн эрхэнд байгаа гэж бодож байжээ. Нөхцөл байдал өөрчлөгдөж. Нина бүх юмыг шийдэж байгаа юм шиг хэрнээ Максимын амыг харна, цаадах нь хэдий дуу цөөтэй ч санаа оноогоо эелдэгхэн хэлэхэд Нина түүний шийдийг тэр дор нь хүлээж авна.

– Арай өөрөөр хэлэх юм уу: энд төвхнөх санаатай байсан чинь юу ч болсонгүй, тэгээд Умард руу дайчлагдана, тэндээс аз жаргалаа хайна гэдэг байгаа. Тэгэнгүүт нь бид өөрснөө Ваняг манайд үлдээ гэж зүтгэсэн юм. Хоёр ч хүрээгүй жаахан амьтан, тэр муу л нийтийн байр, пүнз саваар зовно. Хувь заяагаа төвхнүүлж, боломжийн хүнтэй суувал тэр цагт хүүгээ өөр дээрээ авна биз гэсэн гээд. Ямар вэ, чи юу гэж бодож байна?

– Буян болог, Умард байна уу, Өмнөд байна уу хамаа алга! гэж Варя инээд алдаад, – Зүйтэй! Энэ чинь үнэхээр үнэмшилтэй сонсдоно гэснээ тэсэлгүй Нинаг явуулж, – Энэ санааг намайг сайшааж байна гэж Максимд хэлээрэй гэхив.

Максим хөвүүний явдлыг Варягаас анх сонссоноос хойш тэр хүүхдийн тухай ч, Лена Будягинагийн тухай ч ямар нэг яриа үүсгээгүй. Хорооны шинэхэн дарга гэртээ оройтож ирнэ, чөлөө гарвал Варятай энэхэн тэрхэнээс илүү юм ярихгүй, Ванятай тоглоно, хүү түүнд таалагдаж байгаа, хөвүүн ч түүнийг баярлан тосно.

Тэгтэл нэг удаа, наймдугаар сарын сүүлээр, Ваняг есдүгээр сарын нэгнээс яслид өгөхөөр тохиролцож дөнгөлөө гээд,

– Яслид нэг жил алба хаана, тэгээд гурав хүрэнгүүт нь цолыг нь ахиулж, цэцэрлэгт шилжүүлнэ хэмээн цайлган сэтгэлээр нэмж өгүүлжээ.

Маргааш нь Варя Москва руугаа явж одов.

Ардын дайсны зээг гэртээ орогнуулах – ийм алхам эз мэдсэн хэрэг гэдгийг Максим сайн ухамсарлаж байв. Гэвч хүүхдийг хөөгөөд явуулчихаж чадсангүй. Лена бол авгайнх нь хамгийн дотно найз, өөрөө ч түүнтэй хар багаасаа үерхсэн, Грановскийн гудамжин дахь тэдний байраар нэг бус удаа орж гарч байсан, тэр байшинд дуртай, Иван Григорьевич Будягинд сайн, тэр нь “ардын дайсан” гэдэгт, үнэнч дайчин нөхдийгөө “ардын дайсан” гэж итгээгүйн нэгэн адил итгээгүй яваа. Бас Варяд ч итгэдэг: бүх юмыг зөв хийлээ, хэн нэгэн ухаж төнхөөд учрыг нь мэдэх нь юу л бол. Мэдлээ гэхэд өөрийнх нь буруу гэж юу байх билээ:

нэг бандийг л гэрт нь шургуулчихсан байгаа биз.

Максим худлаа ярих дургүй, арга буюу тэгэхдээ хүрвэл тариачин эрийн хэн ч үнэмшим хээгүй царайгаар ярина. Хорооны комиссар, намын байгууллагын дарга хоёртой зөвлөхдөө дэмий л гараа алдлан,

– Алив ах дүү нар минь бодоцгооё. Нэг муу охин эцэггүй хүүхэд гаргачихаад, энд хүнтэй сууна гээд давхиад ирэх юм. Мэдээж суучихна л даа, боловсролтой, сайхан бүсгүй, манай энд бүсгүйн гачигдалтай байгаа, хүүхэдтэйг ч аваад л сууна. Гэхдээ би хүр охин дүүгээ мэднэ: тэр энд үлдэх юм бол ёстой бөөн юм болно, хамаг авгайчуул нөхөртэйгөө уралцаж өгнө. Хэнээс болж тэгнэ гээч? Хорооны захирагчийн хамаатнаас болж. түүнийг энд байлгахаас арга буюу татгалзлаа. Хонгор минь, хар хүн өөр газраас хай даа л гэж хэлсэн. Тэгсэн чинь: үгүй ээ ер, хүүхдээ өсгөж бойжуулахад минь туслая гэхгүй байх шив, Умард руу дайчлагдана даа гэдэг байгаа! Тэгэнгүүт манай авгай яаж тэсэх вэ: дуртай зүгтээ яв, харин энэ муу жаалыг туйлын шөнө рүү чирж байхын хэрэг юу байна?! Наадах чинь тэртэй тэргүй яс арьс болчихсон амьтан байна! Явуулахгүй! Эндээ үлдээнэ! гэхчлээ. Дүү нь: тэгж л байхгүй юү гэхчээд арилаад өгдөг байгаа даа. Тэгээд одоо хэзээ ирэх юм, ерөөсөө ирэх ч юм уу, үгүй ч юм уу, бүү мэд. Нэгэнт ийм юм болсон хойно, за яахав, тэрэнтэй тэрэнгүй хорооны хүү болгоод хүмүүжүүлчихнэ гэж би бодоод байна. Хороонд маань хэрэгтэй ёс суртахууны байдал ч хэвээр үлдэнэ. Би ийм нэгэн шийд товлоод байна. Та нөхдийн бодлыг сонсоё.

Нөхөд нь түүнтэй санал нийлэв. Хороонд ёс суртахууны байдал өндөр байна гэдэг бол өнөөгийн шатанд хамгийн чухал зорилт, яагаад гэвэл, ёс суртахууны байдал бол улс төрийн байдлын салшгүй хэсэг.

Ворошиловыг гарсны дараа Сталин Молотов руу угасдав:

– Берлинд ингэж мэдэгд: бид яриа хэлэлцээ хийх сонирхолтой байна. Гэтэл германууд яараад байна, бид яарахгүй байгаа, бидэнд яарах шалтгаан байхгүй гэдгийг тэдэнд ойлгуулах хэрэгтэй. Аажмаар гэх үү, үе шагтайгаар гэх үү... томъёоллыг ол. Ингэвэл тэд хөзрөө арга буюу дэлгэж тавина. Хэрэв тэдний санал бидэнд тохирох юм бол тэр үед нь л бид яарах болно.

Гурав хоногийн дараа Молотов Риббентропын хариутай хүрч ирэв. Энэ хариуг Гитлер дуудаж бичүүлсэн, түүнд зориулсан хариу гэдэг нь үг үсэгнээс нь тодорхой байв.

Сталин үг болгоныг эрэгцүүлэн бодож, амандаа зугуухан уншиж эхлэв. Молотов хэдийгээр энэ илгээлтийг нэгэнт сонссон, нэг бус удаа уншсан ч гэсэн анхааралтай чагнав.

– “Ирээдүйд хүрэх зам хоёр оронд маань нээгдлээ. Германд ЗСБНХУ-ын хувьд түрэмгий санаа байхгүй. Герман-зөвлөлтийн харилцаа түүхийнхээ эргэлтийн цэгт ирлээ. Гаргах шийдвэр маань Герман, Зөвлөлтийн ард түмний хувьд хэдэн үеийн туршид шийдвэрлэх ач холбогдолтой байх болно...”

Сталин уншихаа зогсоон Молотов руу харав.

– Энэ муу австр чинь гоё үгэнд юун ч дуртай юм бэ дээ.

Молотов “уран илтгэгч” гэдэг үгийг Сталин дандаа ёгт санаагаар хэлдгийг мэдэхийн учир,

– Уран илтгэгч! гэж өгүүлэв.

Сталин дахиад зугуухан уншиж эхлэв.

– “Герман, ЗСБНХУ хоёрын ашиг сонирхол хаана ч мөргөлдөхгүй байна. Балтийн болон Хар тэнгисийн хооронд хоёр улс бүрэн сэтгэл ханамжтай байхаар зохицуулж болохгүй асуудал байхгүй. (Балтийн тэнгис, Балт орчмын нутаг, Зүүн өмнөд Европ г. м.). Герман, Зөвлөлтийн эдийн засаг бие биенээ харилцан нөхөж болно... Эзэнт улсын гадаад хэргийн сайд фюрерийн үзэл бодлыг ноён Сталинд таниулахын тулд Москвад богино хугацааны айлчлалаар очиход бэлэн байна”.

Сталин цаасыг ширээн дээр тавиад сандлынхаа түшлэгийг налав.

– Ойлгомжтой саналууд байна. Гитлер Польшийн газар нутгаас гадна Балт орчмын нутаг, Финлянд, Бессарабиин тухай ярилцахыг зөвшөөрч байна... Гэхдээ түрэмгийлэгчтэй холбоотон болохыг манай ард түмэн ойлгохгүй, сайшаахгүй. Бид үл довтолцох тухай гэрээ байгуулж болно. Тийм гэрээг манай ард түмэн ойлгоно, дэмжинэ. Тийм гэрээ бол ЗСБНХУ байлдахгүй, зөвлөлтийн ард түмний энх амгалан байдал хангагдсан гэсэн үг болно. Энэ маань бид Польш, Балт орчмын нутаг, Бессараби болон Европын бүс нутаг дахь өөрсдийн ашиг

сонирхлоос татгалзаж байна гэсэн үг мөн үү? Үгүй ээ, тэгсэн үг биш. Гэхдээ үүнийг тусгай, нууц протоколоор тогтоосон байх ёстой.

тэрээр дуугай байзнаснаа үргэлжлүүлэв:

– Манай хойч үеийнхэн хэзээ нэгэн цагт энэ нууц протоколын тухай олж мэдэх нь мэдээж, тэгээд: Сталин, Молотов хоёр яагаад нууц протокол байгуулсан юм бэ? гэж асууна. Большевикууд хэзээ ч нууц гэрээ хэлэлцээрийн эсрэг байсан шүү дээ, большевикууд хаан болон түүний сайд нарын байгуулсан нууц гэрээнүүдийг нийтэлсэн. Тийм ээ, тийм асуулт тавьж чадна. Тийм асуултад хариу бий: хаант засгийн газраас ард түмний эрх ашгийн эсрэг байгуулсан гэрээ бол нэг хэрэг, ажилчин-тариачны засгийн газраас ард түмний эрх ашгийн төлөө байгуулсан нууц гэрээ бол өөр хэрэг. Энэ бол өөр зүйлс. Тэгэхээр ирээдүйн үеийнхэн биднийг ойлгоно. Худалдааны хэлэлцээ яажшуухан урагшилж байна?

– Амжилттай. Энэ сард дуусгах байх гэж бодож байна.

– Асуудлыг ингэж тавих хэрэгтэй: эхлээд худалдааны хэлэлцээр, дараа нь үл довтолцох тухай гэрээ. Тэгвэл германууд манай бүх болзлыг хүлээж авна. Үл довтолцох гэрээ бол германуудын хувьд тэднийг Польш руу довтолсон үед ЗСБНХУ хөндлөнгөөс оролцохгүй байна гэсэн үг болно.

– Англи, Франц хоёр Польшт баталгаа өгсөн гэж Молотов үг хавчуулав.

– Тэд нар Гитлерээс айж байгаа. Ер нь тэгээд, тэд нар Германтай дайн хийхээр шийдвэл бүр л сайн биз. Тэд цөмөөрөө тийм дайнд орооцолдож, өөрсдийгөө туйлдуулна, тэгээд өмнөх дайн хувьсгалаар төгссөн шиг яг тэгж төгсөнө. Бас эцэст нь, Японы өдөөн хатгалтыг зогсоох цаг болжээ. Энэ үүргийг Герман өөртөө авах ёстой, Японы холбоотон юм чинь. Тэгэхээр, Риббентропын илгээлтэд ийм хариу өг: Герман ЗСБНХУ-тай үл довтолцох гэрээ байгуулахад бэлэн үү? Нууц протоколын тухайд гэвэл тэр тухай зөвхөн амаар ярилцана. Тэдний юу санал болгохыг харъя.

Маргааш нь, наймдугаар сарын 16-нд Молотов эдгээр асуултыг Германы элчин сайд Шуленбургт уламжлав.

Наймдугаар сарын 17-нд Шуленбург Риббентропын хариуг Молотовт уншиж өгөв: “Герман ЗСБНХУ-тай үл довтолцох гэрээ байгуулахад болон япон-зөвлөлтийн харилцааг сайжруулахад өөрийн нөлөөг ашиглахад бэлэн байна. Риббентроп маргааш, наймдугаар сарын 18-нд холбогдох хэлэлцээрт гарын үсэг зурах фюрерийн олгосон бүрэн эрхтэйгээр Москвад нисч очиход бэлэн байна”.

Молотов мэгдээд явчихав. Өөрөө ч, Сталин ч маргааш Риббентропыг хүлээн авч чадахгүй: баримт бичгүүдийг бэлтгээгүй байгаа. Тийм учраас Молотов Риббентропын ирэх хугацааг энэ мөчид бүр ойролцоогоор ч тодорхойлох боломжгүй гэж хэлжээ.

Энэ хариултын тухайд Сталин сэтгэл дундуур байв:

– Тийм хариултыг Гитлер өөрийнх нь сайдыг хүлээн авах дургүй байгаа юм байна гэж үнэлэж мэднэ. Бүр ойролцоогоор ч хэлж чадахгүй гэхээр чинь. Чи яагаад чадахгүй байна? Чадна. Худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурмагц Риббентропыг бид хүлээн авна. Германы элчин сайдыг нэн даруй эрж олоод, түүнд ийм хариуг уламжил. Үл довтлолцох гэрээний төслийг гардуул. Тэд нар одоо цаг хугацаагүй юм чинь ямар ч гэрээнд гарын үсэг зурчихна.

Молотов ажилтан нараа хуу дайчилж, Шуленбургийг олж, дахин Кремльд урихыг тушаав. Шуленбург ирлээ. Молотов түүнд үл довтлолцох гэрээний төслийг гардуулаад, худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурсаны дараа Риббентроп Москвад шууд ирж болох юм гэж мэдэгдэв.

Наймдугаар сарын 20-нд хэлэлцээрт гарын зурав. Тэгээд наймдугаар сарын 21-ны 15 цагт Сталинд Гитлерийн өөрийнх нь илгээлтийг гардуулсан байна.

Ноён Сталинд, Москва

1. Би герман-зөвлөлтийн худалдааны шинэ гэрээнд гарын үсэг зурсныг герман-зөвлөлтийн харилцааг өөрчлөн шинэчлэхийн анхны шат гэж үзэж чин сэтгэлээсээ баяр хүргэж байна.
2. Зөвлөлт Холбоот Улстай үл довтлолцох гэрээ байгуулах нь миний хувьд Германы урт хугацааны бодлогыг тодорхойлно гэсэн үг юм. Тийм учраас Герман өнгөрсөн хэдэн зуунд хоёр улсад ашигтай байсан улс төрийн чиг шугамаа сэргээж байна.
3. Ноён Молотовын надад дамжуулсан үл довтлолцох тухай гэрээний төслийг би хүлээн авч байна, тэгээд үүнтэй холбогдсон асуудлыг аль болохоор даруй тодруулах шаардлагатай гэж үзэж байна.
4. Зөвлөлтийн засгийн газрын хүсч байгаа нэмэгдэл протоколыг Германы төрийн хариуцлагатай зүтгэлтэн хэлэлцээ хийхээр Москвад биечлэн очиж чадах юм бол боломжийн богино хугацаанд боловсруулж болно.
5. Польшийн аашилж байгаа байдлаас үзвэл хямрал хэзээ хэзээгүй дэгдэж мэдэхээр байна.
6. Миний гадаад хэргийн сайдыг наймдугаар сарын 22-нд, мягмар гаригт, хамгийн оройтлоо гэхэд, наймдугаар сарын 23-нд, лхагвад хүлээн авахыг дахин санал болгож байна. Эзэнт гүрний гадаад хэргийн сайд үл довтлолцох гэрээ болон протоколыг бүрдүүлэх, гарын үсэг зурах бүрэн эрхтэй байгаа болно. Танаас хариу түргэн авахдаа баяртай байх болно.

Адольф Гитлер

Үүнээс удаан сунжруулж болохгүй. Гитлер хэлэлцээг гартаа авсан байна, аливаа тээг хэлэхийн аргагүй үр дагавартай болж мэднэ.

Тэр өдөрт нь 19 цаг 30 минутад Сталин Гитлерт хариу явуулав.

1939 оны наймдугаар сарын 21

Герман улсын канцлер ноён Гитлерт.

Захиа ирүүлсэнд талархаж байна.

Үл довлолцох тухай гэрээ манай хоёр орны улс төрийн харилцааг сайжруулахад шийдвэрлэх, эргэлтийн цэг болно гэж би найдаж байна.

Манай хоёр орны ард түмэнд бие биетэйгээ эв найртай байх харилцаа хэрэгтэй. Германы засгийн газар үл довлолцох тухай гэрээ байгуулах талаар санал нийлж байгаа нь манай хоёр орны хоорондын улс төрийн хурцадмал байдлыг арилгах, энх тайван, хамтын ажиллагаа тогтоох суурь бий болгож байна.

Зөвлөлтийн засгийн газар ноён Риббентропыг наймдугаар сарын 23-нд Москвад ирэхтэй санал нэгдэж байгааг Танд мэдэгдэх бүрэн эрхийг надад олгосон болно.

И. Сталин

Мөн тэр өдрийн орой, ЗСБНХУ, Англи, Францын цэргийн төлөөлөгчдийн хуралдааны үеэр Ворошиловын туслах түүнд: “Клим ээ, Коба чамайг аргамжаагаа эвх гэж байна” гэсэн зурвас өгөв Зурвасанд гарын үсэг алга, бичиг нь сайн танигдсангүй. Молотовынх ч юм шиг.

Хэлэлцээг мухардалд орсон гэдгээр зогсоов.

Наймдугаар сарын 22-ны өдөр тэр чигээрээ, мөн шөнө нь Риббентропын ирэхтэй холбогдсон бэлтгэлд зориулагдав. Бичиг баримт, орон байр, хамгаалалт, онгоцны буудалд угтах энэ тэрийг бэлтгэв. Цагаан дугуй дотор хар хастай улаан туг буюу Германы төрийн далбааг олохгүй зовсон боловч эцсийн бүлэгт “Мосфильм”-ээс олжээ. Фашистын эсрэг кино авахад ашиглаж байгаад хожим хэрэг болно гэж хадгалж байсан юмсанж.

Сталин зуслан руугаа явсангүй, баримт бичгийг батлан, яриандаа бэлтгэж хотод хоножээ. Хэнтэй учрахаа мэдэж байх ёстой учраас Риббентропын тухай лавлахыг уншив. Риббентроп залуудаа дарсны наймааны ганзагын төлөөлөгч хийж байгаад нацистуудтай нийлж, Англид элчин сайд болсон, одоо гадаад хэргийн сайд. Улсдаа Гитлерийн дараа ордог, хоёр дахь хүн Герингийн үнэлгээ түүний анхаарлыг татав. “Залхуу, ажлын мэдлэггүй, тогос шиг нэр алдарт дуртай, ихэмсэг, хошин шогийн мэдрэмж байхгүй. Риббентропын нэр дэвшсэнийг буруушаан, тэр чинь Английн холбогдолтой ажил явдлыг дөнгөхгүй гэж намайг шүүмжлэхэд фюрер надад Риббентроп тийм ч нэг лордыг танина, ийм ч нэг сайдыг танина гэж хэлсэн. Би тэгэхэд нь: ‘Тэд нар нь Риббентропыг бас мэддэгт л хамаг зовлон байна шүү дээ’ гэж хариулсан.

Ингэж бие биенээ чимхэхийг Гитлер, мэдээж, өөгшүүлнэ. Эзэнтэн эргэн тойронд нь нягтарсан эвтэй хүрээлэл байхыг тэвчдэггүй, тийм хүрээлэл үгсээд ар худрагаар нь

хуйвалдаж мэднэ. Тийм учраас Герингийн үгийг шүүмжлэлтэй хүлээж авах хэрэгтэй. Гитлер гадаад хэргийн сайдын албанд залхуу, ажлын мэдлэггүй улс төрчийг барьж байна гэж байхгүй. Сэтгүүлчид бол түүнийг, харин ч эсрэгээр, ажлын чадвар сайтай, шийдэмгий, бүдүүлэг, шижээргүй хүн гэж тодорхойлдог. Германы гадаад бодлогын амжилт үүнийг нотолж байна. Ихэмсэг зангийн тухайд гэвэл, дипломатын хувьд ихэмсэг зан бол тактикийн арга, ялангуяа бодлого түрэмгий байхад тийм байдаг. Гэвч одоо хийх гэж байгаа яриа хэлэлцээн дээр Риббентроп долдойчлон зулгуйдна, есдүгээр сарын нэгэн хүртэл ганцхан долоо хоног үлдсэн, Гитлер, тэр хоёр түүний гарт байгаа. Харин их зантай байвал тэрээр түүнийг дорхон нь номхруулна.

Одоо, Риббентропын ирэхийн өмнө, тэрээр бүх юмыг өөрийнхөө хувьд нэгмөсөн шийдсэн байх ёстой. түүний шийдвэр Зөвлөлт Холбоот Улсын хувь заяаг, Европын хувь заяаг, бүх дэлхийн хувь заяаг урт удаан хугацаагаар тодорхойлно. Гол асуулт: өөрөө Гитлерт итгэж байгаа билүү? Германы дивизүүд дараа нь Зөвлөлт рүү дайрахын тулд Польшоор маршлан алхах юм биш биз?

Улс төрийн бодлого дээр хэнд ч итгэдэггүй, зөвхөн өөртөө итгэдэг. Гитлерийг онцгой зөн билэгтэй гэлцдэг. Донгосоон! Зөн билэг дандаа сийрэгхэн ухаанаар хийсэн тооцооны үр дагавар байдаг. Тооцооноос үзвэл Гитлер Польшийн дараа Франц руу дайрна. Гитлерийн занг оношлох аргагүй гэлцдэг. Аугаа их улс төрчид суут мэргэ нь шаардаж байвал бодлогоо эрс өөрчилдөг, тэдний тэр чадварыг оношлогдошгүй байдал гэж үздэг. түүний Гитлертэй гэрээ байгуулахыг бас оношлогдошгүй байдал гэж тайлбарлах болно. Үнэн хэрэгтээ энэ бол Зөвлөлт Холбоот Улсын алс хэтийн ашиг сонирхолд нийцсэн, сайтар цэгнэсэн алхам.

Гитлерийг хувь хүнийх нь хувьд таахад бэрх гэдэг нь эргэлзээгүй. Тэр хажуу халимаг, сахал энэ тэрийг нь харвал агуу улс төрийн зүтгэлтэнтэй төсгүй. Хэдий тийм ч тэр бол гарцаагүй агуу улс төрийн зүтгэлтэн. Гитлер агуу ихийн дэмийрэлтэй, алхам тутамдаа суу билгээ, эрхэм дээд зориулгаа цохож байдаг гэлцдэг. Зөвлөлтийн хүний хувьд тэгж өөрийгөө дөвийлгөх нь заншаагүй зүйл, зөвлөлтийн хүн захирагчийнхаа даруу занг юуны өмнө үнэлдэг. Жолоодогчийн тухай германууд өөр төсөөлөлтэй бололтой, тэд нар сүржин байдалд дуртай. Гэхдээ гагцхүү өөрийнхөө суу билэгт итгэдэг хүн л бусдад тийм итгэл төрүүлж чадна. Харин тэр суу билгийнхээ тухай ярих, эс ярих бол... тэрээр өөрийнхөө суу билгийн тухай хэзээ ч ярьдаггүй, түүний оронд бусад хүн ярьдаг. Гитлер өөрөө ярихыг илүүд үзэж байна. Тэр бол түүний хэрэг. Гэхдээ энэ бол агуу ихийн дэмийрэл биш. Агуу ихийн дэмийрэл гэж агуу нь байхгүй, дэмийрэл нь байгааг хэлнэ. Гитлер зургаан жилийн дотор Германыг үнсэн товрогоос босгож ирсэн, замбараагүй байдлыг гэтэлсэн, дэг журам тогтоосон, аж үйлдвэрийн өсөлтийг хангасан, ажилгүйдлийг устгасан, хүчирхэг арми, флот, нисэх хүчнийг байгуулж зэвсэглэсэн, Версалийн гинжийг тас цохиж, нэг ч герман хүний гарзгүйгээр Австри, Чехословак хоёрыг нэгтгэж авсан, улсынхаа хүн амыг арван саяар нэмэгдүүлсэн, стратегийн хувьд чухал ач холбогдолтой асар уудам газар нутгийг булаан эзэлсэн, гар мухар, цөлмүүлсэн Германыг ялзарч, гандаж, дараа дараалан баларч байгаа Англи, Франц хоёр өмнө нь чичирдэг лут хүчирхэг улс болгосон энэ тэрийг хүлээн зөвшөөрөхгүй байж болохгүй.

тэрээр хэн дээр бооцоогоо тавих вэ? Цаг хугацааг угтаж байгаа Гитлер дээр үү, эсвэл цаг

хугацаа нь өнгөрч байгаа өрнөдийн ардчилсан улсууд дээр үү? тэрээр хэнийг хамгаалах вэ? Дөрвөн сая хагас украинчууд, бүтэн хагас сая белорусыг боолчилсон Польшийн онгиороо язгууртнуудыг уу? Хуваагдаж тарчилсан Чехословак руу бүр өнгөрсөн жил дэлт бүргэд шиг дайрч, Тешинийн Силезийг нь булааж авсан Польшийг хамгаалах уу?! Польшийг ихэмсэг тэнэгүүд жолоодож байгаа нь түүний буруу биш. Германуудад Данцигийг нь яагаад өгсөнгүй вэ? Данциг чинь Германы хот шүү дээ. Өөрийнхөө нутаг дэвсгэрээр зөвлөлтийн цэргийг гаргахаас яагаад татгалзав? Тэд нар Орос, Герман хоёртой зэрэг муудалцахаар тийм хүчтэй юм гэж үү? Польшууд хэзээ ч дуулгаваргүй ард түмэн байсан, одоо ч бас бодит бодлого явуулахыг хүсэхгүй байна. Лайгаа эдэлцгээг. Польш алдааныхаа тухай бодоход одоо оройтсон. Риббентроп маргааш Москвад ирнэ, тэгээд тэрээр Гитлертэй гэрээ байгуулна. Энэ холбооны тухай өөрөө аль хэзээнээс бодсон, Гитлер тийм холбоо байгуулна гэж итгэж байсан, түүний итгэл эцсийн бүлэгт зөвлөө, зөвтөхгүй байх ч ёсгүй. Өрнөдийн ардчилсан орнуудтай нэгдэнэ гэдэг бол өөрийгөө илт ялагдлын замд оруулна гэсэн үг. Үүнийг тэрээр ойлгож байгаа, Гитлер ч бас ойлгож байгаа.

Орчин үеийн хамгийн агуу энэ хоёр зүтгэлтэн, өөрсдийнхөө үзэн яддаг олон улсын хөрөнгөтний бахыг хангахаар, тэдний ноёлогч баячуудыг баярлуулахаар, бие биенээ харилцан сүйрүүлэх дайн хийж, өөрсдийн ард түмнийг, өөрсдийн улс гүрнийг, бас өөрсдийгөө үнэхээр хөнөөнө гэж үү? Англи, Францын империалистууд мөлжиж байгаа энэ гариг дээр Гитлер, ТЭР хоёрт, тэдний ард түмэнд, тэдний улс оронд хангалттай газар үнэхээр байхгүй гэж үү? Дэлхий асар том, түүн дээр Орост ч, Германд ч хангалттай нутаг дэвсгэр бий. Тэд нар дэлхийг эзэмдсэн цагт зэрэгцэн орших аргаа олно. Хэрэвзаяа хойч үеийнхэн нь тэдний өвийг хадгалж чадахгүй бол тэр хойч үеийнхний өөрсдийнх нь л хохь болно.

“Дорно зүгийн нутаг дэвсгэрийн” тухай Гитлер хорин дөрвөн онд бичиж байсан. Орос тэгэхэд тамиргүй байсан учир хялбар олз шиг санагдаж байж. Цаашдаа Гитлер энэ сэдвээ Өрнөдийг мэхлэхийн тулд, өөрийгөө зэвсэглэхэд Өрнөдийг саад болгохгүйн тулд хэвээр байлгаад байсан. Одоо дэлхий дээр хүчний харьцаа өөр болсон, Гитлер арга саам хийхээ нэгэнт болиод, гол зорилго руугаа шууд явж байна.

Хэд хоногийн өмнө Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Рузвельт Молотовт: “Хэрэв зөвлөлт засгийн газар Гитлертэй холбоо тогтоох юм бол, Гитлер Францыг эзэлмэгц цэргээ Орос руу хөдөлгөнө гэдэг нь тэнгэрийн нар шиг тодорхой байна” гэсэн цахилгаан ирүүлсэн. Рузвельт юуг ойлгож байна вэ? Тэр бол зөвхөн америк банкны эздийн ашиг сонирхлыг л ойлгож байна. Америк банкны эзэд хүчтэй нэгдмэл Европыг харах хүсэлгүй байгаа нь эргэлзээгүй. Тэд өөр Европтой: сүйрсэн Зөвлөлттэй, сүйрсэн Германтай, ялзарч байгаа Францтай, гандаж байгаа Англитай Европ буюу америк банкны эздэд дуулгавартай Европтой харилцахыг илүүд үзэж байгаа. Рузвельт тийм Европыг заяа нь үзэхгүй.

тэрээр асуудлыг шийдсэн. Бүрэн төгс шийдсэн. Одоо Гитлер бас энэ бүрэн төгс шийдвэрт хүрсэн байна.

Испанийн коммунист Жак Морнар Парист очиж байгаа, түүнийг Зборовскийтэй уулзуулвал зохино. Зборовский Морнарыг болох гэж байгаа троцкист конгрессийн нэг оролцогч Сильвия Агелоф гэдэг америкийн троцкист эмэгтэйтэй танилцуулна. Эйтингоноос ийм даалгавар иржээ. Шарок Зборовскийд үүнийг уламжлаад, тэр авхайн тухай ярьж өгөхийг хүсэв.

– Авхай биш бүсгүй гэж Зборовский тодотгоод, – Орчуулагч, франц, итали, испаниар чөлөөтэй ярина, англиар мэдээж, бас орос хэл мэднэ, эх нь орос. Эгч Рут нь Мексикт, Койоаканд, Троцкийн хувийн нарийн бичгийн дарга нарын газарт ажилладаг. Сильвияг эгч дээрээ очиход нь түүнийг бас нарийн бичгийн дарга нарын газарт татан ажиллуулна. Лев Давидович ч, Наталья Ивановна Седова ч түүнд сайн, түүнийг үнэлдэг, туйлаас итгэдэг юм гэв.

Зборовский Сильвия Агелофт талтай байдаг нь дууных нь өнгөнөөс мэдэгдэж байв. Тэр Лев Седовт ч бас найрсаг ханддаг байсан, гэхдээ тэр нь түүнийг өөр ертөнц рүү тонилгоход саад болоогүй. Гэвч мань хүн урьдын адил Троцкийн эрх ашгийг Парист төлөөлж, “Сөрөг хүчний сэтгүүлийг” гаргасаар буй. Чухам үүнээс болж Троцкий түүнийг Европт илүү хэрэгтэй гээд Мексик рүү шилжүүлэхээс татгалзаад байгаа гэж Зборовский нотолдог. Гэхдээ талийгаач хүүг нь өдөр болгон санагдуулах хүн хажууд нь байхад Троцкий, авгай хоёрт хэцүү байж мэднэ гэдгийг Зборовский зөвшөөрдөг. Шарок эдгээр тайлбарыг буруушаадаггүй ч гэсэн Троцкий өөрөө юм уу, эсвэл ойр тойрныхны нь хэн нэгэн Зборовскийд итгэхээ больсон, тэгээд өөр рүүгээ очуулахгүй байгаа гэж бат итгэж байгаа билээ. Тийм учраас Судоплатов, Эйтингон хоёрын товлосон, бас Шарокийн яг цагт нь, яг онож хэлсэн Койоакан руу нэвтрэх зам л цорын ганц зөв зам.

Морнар гэдэг нүдний шилтэй, сахалтай, бахалтай, бага шиг хуузтай өндөр гоё испанийг Шарок шууд танив. Москвагийн хаяанд байх ДЯАК-ын тагнуулын сургууль дээр гучин долоон оны хоёрдугаар сард түүнийг харсан болоод тэр. Тэр үед сахал, бахлын аль нь ч байгаагүй, Рамон бил үү, Лопес бил үү, өөр л нэртэй байсан. Өөртэй нь хамт цанаар явна гэж зүтгэсэн учраас Шарок түүнийг тогтоож авчээ. Цанаар ерөөсөө явж үзээгүй хэрнээ тэгэхэд явна гэж зүтгэсэн. Гурвуулаа явсан: мань хүн, Шарок, швед бил үү, норвег бил үү Арвид. Арвид хурдлаад моддын цаагуур алга болсон, мань хүн цана нь ч мултрад, өөрөө ч сав л хийвэл ойчоод байсан хэдий ч Шарокийн араас улайран зүтгэж асан. Нэмэрт нь, хөнгөхөн хувцастай, малгайгүй явсан, гэтэл гэнэт шуураад эхэлсэн, хоёрдугаар сар юм чинь. Шарок түүнийг өрөвдөөд: “Чи буцсан нь дээр. Салхинд цохиулчихна!” гэж хэлсэн. Испани залуу гоморхон бараг ууртай хараад буцсан. Тэр гоморхуу, түрэмгий занг нь Шарок тогтоож авсан юмсанж.

Тийм учраас энэ бол ямар ч Жак Морнар биш, бельги паспорт нь мэдээж хүнийх, Испаниас олж авсан байж таарна. Сайн дурынхныг Испанид ирмэгц паспортыг нь хурааж аваад, Москва руу багц багцаар нь явуулна. Алагдагсдын паспортыг эзнийх нь намтар, гэр бүл, хамаатан садныг нь сайтар судалсны дараа манай тагнуулын албаны агентад олгодог байсан юм.

Жак Морнарын паспорт алагдсан бельги хүнийх үү, эсвэл хуурамч уу, чухам аль нь болохыг Шарок мэдэхгүй, гэхдээ паспортоороо гучин гуравтай байгаа нь түүнд зургаа, долоо нас нэмчихсэн гэсэн үг. Арай ахимаг харагдахын тулд мань хүн сахал, бахал тавьжээ. Сэтгэлийг нь татах ёстой Сильвия Агелоф нь хорин наймтай.

Шарок бас сахал, бахалтай. Испани маань түүнийг таньсан уу, үгүй юү? Хэлэхэд хэцүү. Мэдсэн царай харуулаагүй. Бас оросоор нэг ч үг дуугараагүй.

Шарок Морнарыг Зборовскийтэй уулзуулав. Морнар Эйтингоны боловсруулсан намтарын хувилбараа мэдээлэв: Морнарын эцэг нь Тегеранд суугаа Бельгийн консул, Морнар сурвалжит гэр бүлээсээ үзэл санааны шалтгаанаар харилцаагаа тасалсан, дэлхийд ноёрхож байгаа нийгмийн шудрага бус байдлыг харж байгаа, гэхдээ улс төрийн бодлогыг хайхардаггүй, тийм юмаар оролдох хүсэлгүй, Парист Бельгийн хэвлэлийн агентлагт гэрэл зургийн сурвалжлагчаар ажиллана. түүнээс гадна Эйтингон түүнийг Сильвиягаар дамжуулан Троцкийн дотнын нөхөд болох авгай, нөхөр Росмерээс итгэл олж авахыг үүрэгдсэн. Чухам тэдний шилтгээнд троцкист конгресс болох юм.

Морнарт гэрэл зургийн сурвалжлагч гэж улс төрөөс хол мэрэгжил сонгосон Эйтингоны ухааныг Шарок зохих ёсоор үнэлэв.

Хэд хоногийн дараа Зборовский утасдаж, танилцуулах ажил маргааш Николо гудамжны кафед, өдрийн нэг цагт болно гэж хэлэв. Морнар тэр хоёр арваад минутын өмнө очно.

Шарок яльгүй хойхно ирж, Зборовский, Морнар хоёрын дэргэдүүр өнгөрч, тэднийг ил харж байхын тулд холгүй суув.

Кафед хоёр хүүхэн орж ирэхэд Зборовский босч өөдөөс нь очив. Хуучин тодорхойлолтын дагуу хэн нь Сильвия болохыг Шарок төвөггүй танив. Дунд зэргийн нуруутай, биеийн гальбар дажгүй ч, хараа булаагаад байх юмгүй, шар үстэй, нурамгар хүүхэн. Морнарт атаархах юм алга. Ийм сайхан залуу түүнд дурлана гэж үү? Хэн итгэх юм бэ? Гэвч даалгавар бол даалгавар юм чинь бултаж зайлахын арга байхгүй.

Зборовский хоёр хүүхнийг ширээ рүүгээ дагуулж ирэхэд Морнар бослоо. Бүгдээрээ гар барин мэндлээд сууцгаав. Шарок өөрийнхөө тэндээс тэднийг тодхон харж байлаа. Хэдийгээр аяархан ярилцаж байгаа ч хэн нэг нь дуугаа чангалвал түүнд ганц нэг салангад үг сонсдох аж. Сильвия Морнарын увидаст автах нь уу, үгүй юү? Ийм хүүхнүүд улс төрөөр хөөцөлдөөд эсвэл хүнтэй суухгүй ганц биеэрээ үлддэг, эсвэл үзэл бодол нэгтэй нэг эрэмдэгтэй суудаг. Гэтэл Морнар бол улс төрд харанхуй хүн. Тэр хоёрын хооронд ямар “харилцан ойлголцол”, ямар “үзэл санааны дотносол” байх вэ? Гагцхүү бие махбодийн дотносол байж болно. Ямар ч хүүхэн өөрийнхөө боломжийг тооцоолдог, байгалиас юу заяасан, юу эс заяасныг мэддэг. Сильвиягийн ганц найдвар бол биеийнх нь гальбар. Энэ мэдээж чухал. Хүүхэн сайхан биетэй бол, түүнтэй оронд ороход сайхан...

Энэ зуур Зборовскийн ширээний ард яриа хөөрөө улам бүр хөгжилтэй болж байна. Морнар нэг юм яриад, Сильвия инээгээд л. Шарок үйлчлэгчтэй тооцоо хийж, үүд рүү зүглэх зуур Морнарт горьдлого байна гэж бодов.

Морнар өөрийнхөө боломжийг ашиглаж чадсан байна. Зборовскийн ярьж байгаагаар бол нөгөө хоёр өдөр болгон уулзаж, театр, ресторанд ордог аж. Морнар машинаараа Сильвияг Росмерийнхэнд хүргэж өгөөд дараа нь авахаар буцаж иржээ. Сильвия түүнийг гэрийн эзэдтэй танилцуулсан байна. Бүх юм дажгүй явж байна.

Росмерийнхний шилтгээнд IV Интернационалын зохион байгуулах конгресс боллоо. Зборовский Шарокт тунхаг болон тэнд баталсан бусад баримт бичгийг дамжуулав. Сонинд нийтлэгдсэн Троцкийн өгүүллийг бас дамжуулав: “Большевик намыг боомилж, ажилчны анхны улсыг булай шог зураг болгоход Кремлийн бүүрлэгч бүлгийнхэнд арван жил шаардагдлаа... Дөнгөж арван жил... Тэгвэл IV Интернационалын хөтөлбөр ойрын арван жилд сая сая хүний замыг заагч од болж, тэд нар газар, тэнгэрийг яаж дайрахыг мэдэх болно!” Энэ бүхнийг Шарок Москва руу илгээжээ.

Тэгж тэгж Зборовский ингэж мэдээлэв: Морнар, Сильвия хоёр Парисын төвд, Эх Дагинын сүмийн дэргэд хоёр өрөөтэй байранд орсон. Өглөөний цайгаа Дуурийн талбай дээрх америк бааранд ууцгааж байгаа. Ийнхүү Эйтингоны даалгавар биелэлээ. Шарокийн хувьд Морнарт мөнгө өгөх, ихээхэн мөнгө өгөх л ажил үлджээ.

Лена болзсон өдөр, товлосон цагтаа хаалганы хонхыг дарав. Явах, явахгүй нь мэддэгддэггүй энэ хотын автобусаар цаг тооцоолоход хэцүү, гэвч хэзээний цаг нарийн барьдаг түүний тооцоо зөв болж таарчээ.

Саша пальтогоо тайлахад нь туслах зуур,

– Амархан олов уу? гэж асуув.

– Тэгж нарийн зааж өгсөн юм чинь би яаж төөрөх вэ.

Саша цай чанаж, хиам, бяслагаар хачирласан талх, чихэр, нэг шил улаан дарс энэ тэрийг ширээн дээр тавилав. Өчигдөр зэхсэн юм байж. Лена,

– Ганцхан дуслаас л толгой эргээд байх юм гээд дарснаас татгалзав.

Шуудан дээр байсныг бодвол биеэ барих нь гайгүй байна.

– Тэгвэл уулзсаны төлөө би ууна аа гээд Саша аяганы талаар дарсхийж татлаа.

– За, Леночка, би эхлээд өөрийнхөө ажил байдлыг чамд ярья, дараа нь чи өөрийнхийгөө ярьж өгөөрэй. Цөллөгний дараа хар дансанд орсон, том хотуудад суух эрхгүй, тэгээд л жижиг хотуудаар тэнүүчилж явна. Над шиг биеийн байцаалтай хүн ердийн ажилд орно гэвэл бөөн хөөцөлдөөн болно, тийм учраас би ердийн биш ажил болохоор нь өрнөд европын бүжиг зааж байна. Чамтай танилцуулсан Глеб бол миний хөгжмийн хамтрагч, шалгагдсан үнэнч нөхөр, түүнээс чи болгоомжлохгүй байж болно. Ээжтэй утсаар байнга ярьж байгаа, ээж маань ганцаараа байгаа. Эцэг шинэ гэр бүлтэй, өөр хотод ажиллаж байгаа. Нагац ах Марк маань буудуулсан. Миний ажил явдал нэг иймэрхүү. Чамтай холбоотой юм би юу мэдэж байгаа гээч? Иван Григорьевич, Ашхен Степановна хоёр гучин долоон онд баривчлагдсан. Чамд хүү бий, эцэг нь миний дуулснаар бол Юра Шарок, гэхдээ чи түүнээс харилцаагаа тасалсан юм уу даа. Найз нарын тухайд гэвэл: Макс Алс Дорнодод байгаа, Зөвлөлтийн баатар. Нина Иванова түүний авгай. Вадим Марасевич дээгүүр жаалдаг шүүмжлэгч, миний ойлгож байгаагаар бол яггүй үл бүтэх этгээд. Өөрийнхөө тухай, чиний тухай, бидний дундын танилын тухай миний мэдэх юм ингээд гүйцлээ. Одоо чи ярь, мэдээж, хэрэгтэй гэж үзэж байгаага л ярина биз.

Лена түүн рүү духайсхийн харав.

– Намайг чамд итгэдэггүй гэж бодоо юу?

– Леночка, үл итгэх чинь энэ эриний туг. Тийм учраас би чамайг илэн далангүй бай гэж уриалахгүй. Гэхдээ миний тус хэрэгтэй байж болно, тэгвэл би бэлэн шүү.

– Саша, би чамд хэзээний итгэдэг, одоо ч итгэж байна. Чи голыг нь мэдэж байгаа юм байна. Нэмж хэлэхэд: аавыг буудан алсан, надаас нэг ч эргэлт оруулаагүй. Үүнийг хүн буудан

алуулсны анхны тэмдэг гэлцдэг юм билээ, ээжийг бас тэгсэн байх. Миний дүү Владлен, чи түүнийг санаж байгаа, ДЯАК-ын хүүхэд хуваарилах газар байгаа, Ваня хүүг маань сайн улс өсгөж байгаа. Надад Москваг орхиж явахыг тушаагаад, хот сонго гэж хэлсэн, би Уфаг сонгож ирсэн, Егор Сазановын гудамжин дахь ДЯАК-ын газарт сард нэг удаа очиж тэмдэглүүлдэг. “Нефтегаз”-д ажиллаж байгаа, нийтийн байранд сууж байна.

– Юу хийхэв?

– Барилга дээр ажиллана, төмөр замын зөрлөгийн засвараас хийлцэнэ. Амаргүй ажил, харин дажгүй цалинтай.

– Дэр мод энэ тэр чирэх үү?

– Дэр мод ч чирэх явдал гарна. Надад энэ бол болж байгаа: Машад мөнгө явуулах боломжтой, Владлений асрагч байсан авгай, дүүг маань баллуулчихгүй байж чадна.

Саша ханиаж хоолойгоо засаад, дахин хагас аяга дарс хийж ув.

– За чи тийм ажилтай байдаг байж, дэр мод чирээд л. Эрхиш бээлий өгнө биз дээ.

– Өгнө. Энэ бүхэн мэдээж түр зуурынх. Москвагаас ийм байдлаар хөөгдсөн “ардын дайсны гэр бүлийн гишүүдийг” бүгдийг нь хорих газар рүү аль хэдийн явуулчихсан. Намайг ч энэ тойрохгүй. Манайтай зэргэлдээ хорихын цэг байгаа, тийм учраас нэг амбаараас нөгөөд, гэхдээ өргөст тортойд шилжүүлчихнэ. Чи бидний танилуудын хувьд гэвэл, Нина Макс руу яваад өгсөн нь үнэн, үүнийг нууцалдаг юм, гэхдээ чи нэгэнт мэдэж байгаа хойно, чамаас нуух юм алга. Вадим? Эгч Вика нь франц хүнтэй суугаад, Парист аж төрж байгаа, мань Вадим “гадаадад төрөл төрөгсөдтэй” болсон, тэгээд засгийн өмнө гойд хичээж байгаа.

– Яагаад юм идэхгүй байна? Цай уу, хөрчихнө.

Лена хачиртай талх авч, аягатай цайнаас балгав.

– Нууц биш бол чи ямар овогтой яваагаа хэлэхгүй юү?

– Өөрийнхөөрөө. Будягина.

– Чи өөр ажил хайх гэж үзсэн үү?

– Ямар?

– Чи чинь олон хэл мэднэ шүү дээ.

– Сашенька, хонгор минь, хэлээр хийх ажил энд надад хэн өгөх юм бэ? Дунд, дээд сургуульд багшийн ажилд оруулах уу?

Сашагийн толгойд нэг санаандгүй бодол орж ирэв.

– Чи төгөлдөр хуур сайн тоглодог шүү дээ.

– Тоглодог. Сайн, мууг би мэдэхгүй.

– Чи өнөөдөр завтай юу?

– Юу гэж?

– Хоёулаа Хөдөлмөрийн ордон руу очъё, би тэнд бүжиг заадаг юм. Миний яаж заадгийг харахгүй юу.

– Өнөөдөр үү? гээд Лена цагаа харснаа, – За тэгье. Чамайг бүжгийн багш гэж сайн төсөөлж чадахгүй л байна гэв.

– Би бол чиний дэр мод зөөж байгааг төсөөлөхгүй байна.

– Тийм шүү. Үүнийг би заримдаа өр төлөөс гэж боддог юм.

– Өр төлөөс өө? Юуны?

– Эцэг нарын маань нүглийн.

– Чи юуг хэлээд байна?

– Бүх юмыг. Улааны алан хядлага, Онцгой комисс, Улс төрийн ерөнхий газар. Болж өнгөрсөн бүх юмны өр төлөөс. Тэд нар чинь улс орны удирдагч байсан, ард түмний хувь заяаг хариуцаж байсан.

Саша дахин нэг хагас аяга дарс хийгээд Лена руу харснаа инээд алдав.

– Аав аа, битгий уу л даа! Хаана ингэж байдгийг санаж байна уу?

– Их л танил юм... Гэхдээ хаана байдгийг санахгүй байна...

– Чеховын “Хүзүүн дэх Анна”.

Лена бас инээд алдав.

– Өө, тийм шүү дээ, “Хүзүүн дэх Анна”. Яг зүйтэй: “Аав аа, битгий уу л даа!”

– Леночка, бүгдийг нь нэг юм руу чихэж болохгүй. Улааны алан хядлага цагааны алан хядлагыг дагаж гарсан, аль аль талаасаа үйлдсэн муухай харгислал. Хувьсгал гэдэг бол эрс эргэлт, уул нуралт, энэ нуралтыг зайлуулж чадаагүй хүмүүс л буруутай.

Саша дарсаа гүйцээж уугаад бодолхийлснээ үргэлжлүүлэв:

– Хорин нэгэн онд иргэний дайн дууссан, тэгтэл хүчирхийллийн аргаар коммунизм байгуулж болохгүй нь илэрхий болсон. Тэгээд хөдөлгөөн нөгөө тийшээ эргээд явчихсан. НЭП (Шинэ

эдийн засгийн бодлого) бол өөрчлөлтийг аажмаар, уршиг багатай хийхээр тооцоолсон зүйл. Гэтэл НЭП-ийг хөсөр хаясан, тэгээд бид юу олж долоосон, хэнийг олж долоосон нь энэ. Үүнд л манай эцэг нар буруутай. Тэд сэрэмжлэн зайлуулаагүй, эрх мэдэлтэй байснаа гэмт этгээдийн гарт үг дуугүй өгсөн. Энэ тухайд буруутай. Би ч бас буруутай...

– Чи юугаараа буруутай гэж?

– Манай ангийн Соня Шварцыг санаж байна уу?

– Саналгүй яахав, би сургуулиас хойш түүнтэй тааралдсан. Их сургууль төгссөн, академич эцэг шигээ бас физикч.

– Би ч бас түүнтэй Арбатад нэг таарсан, мэдээж, ангийнхныгаа, хүүхдүүдээ, багш нарыгаа эргэн дурссан, тэгсэн чинь нөгөөх чинь инээгээд: “Чи мэдэх үү, Саша, сургуульд байхын л би чамаас айдаг байсан” гэсэн. — “Айж байсаан? Яагаад?” — “Яагаадыг мэдэхгүй. Ямар ч байсан их айдаг байсан”. Тэгээд би: Тэр яагаад надаас айж байсан юм бол? Би аймшигтай байсан юм уу, хэн нэгнийг гомдоож байсан юм уу? гэж бодож билээ.

– Хаанаас даа, бид цөмөөрөө чамд сайн байсан шүү дээ!

– Гэтэл тэр айж байсан байна. Яагаад гэдгийг нь би ойлгосон. Комсомолын гишүүн би түүний хувьд айдас дээр суурилсан системийн биелэл болж байж. Тэр айдсыг би түүнд төрүүлээд байсан байна, миний буруу тэр. Тийм учраас чиний эцэг ч, чиний ээж ч, би ч буруутай. Харин чи бол үгүй! Чи үүнийг өр төлөөс гэж нэрлэж байна, би бол дур зоргын авирлал гэнэ. Бидний зорилт бол эсэн мэнд үлдэх. Биднийг илүү сайхан цаг хүлээж байж магадгүй.

– Чи тэгж итгэж байна уу? Эсвэл намайг тайтгаруулах гэж бодож олов уу?

– Итгэж байгаа. Тийм учраас бид эсэн мэнд үлдэх ёстой гэж чамд хэлж байна, үгүйдээн ойр дотныхныхоо төлөө: чамд хүү, надад ээж байна. Ингэхэд чи ээжтэй уулзаад удаж байна уу?

Лена газар шагайв.

– Саша, би чиний өмнө түмэн буруутай, би ээж дээр чинь нэг ч удаа очоогүй. Бас үүний ч өр төлөөс.

Саша инээд алдав:

– Би чамайг ээж дээр очиж байсан уу, үгүй юү гэдгийг мэдэх гэж ээжийнхээ тухай асуусан юм биш, шал өөр шалтгаанаар асуусан юм. Шуудан дээр тааралдахад чи уулзсандаа ерөөсөө гайхахгүй байх шиг надад санагдсан, тэгээд намайг Уфад байгаа гэж ээжээс дуулсан юм болов уу гэж бодохгүй юү.

– Тийм шүү, чамайг энд байгаа гэж би мэдэж байсан. Гэхдээ ээжээс чинь мэдсэн юм биш. Надад энэ тухай Нина Ивановагийн дүү Варя хэлсэн юм.

– Варя... Чи уулздаг, нөхөрлөдөг байсан юм уу?

– Тэр бид хоёр олон удаа уулзалдсан, сүүлийн үед тэр манайхаар байн байн ирдэг болсон. Чи түүнийг жаахан охин байхыг нь санах байх.

– Сурагч байсныг нь санаж байна гэж Саша товчхон хариулав.

– Сурагч биш болоод зөндөөн удаж байгаа. Тэр надаас хэрсүү, илүү хар ухаантай юм шиг заримдаа надад санагддаг байсан, надаас чанга гэдгийн тухай бол ярихын ч хэрэггүй. Намайг зовлонгоос чангааж гаргана, бүх утгаар чангааж гаргана. Эцэг эхийг маань баривчилсны дараа намайг тэр дор нь ажлаас халчихсан. Би бүр шал угаах ажилд ч орж чадахгүй байлаа. Гэтэл миний гар дээр дүү, хүү хоёр маань байгаа...

тэрээр ширээний араас босч, цонх руу очсон нь догдолж буйгаа Сашад харуулахгүй гэсэн хэрэг.

– Салхинд хийссэн мэт бүх найз маань алга болчих нь тэр. Тэгтэл гэнэт Варятай таарлаа. Санаандгүй. Гудамжинд. Би Бурханд сүсэглэдэг байсан бол түүний төлөө өдөр болгон мөргөл үйлдэх ёстой байсан! Гэхдээ би залбирч байгаа: би уншлага мэдэхгүй, өөрийнхөө үгээр залбирч байгаа. Жирийн шугам зүрагчин, рубль болгоноо тооцож байгаа хэрнээ биднийг яаж тэтгэж байсан тухай би ярихгүй байна. Варя Ванечкаг аварсан.

Лена Саша руу эргэж сонжсон янзтай харав.

– Миний хүүг хамаатнууд руугаа аваачсан.

– Нина дээр үү?

– Тийм. Энэ тухай хэн ч мэдэхгүй, Саша.

– Хойшид ч мэдэхгүй, битгий санаа зов.

– Алс Дорнод руу аваачих бол амаргүй. Ванягийн төрсний гэрчилгээнд: эх –Будягина Елена Ивановна гэж бичээстэй, гэтэл үнэмлэх Варвара Сергеевна Иванова гэсэн нэр дээр байгаа. түүний яаж азаа үзсэнийг чи төсөөлж байна уу? Хүүхдийг нь булаагаад авч болох байсан, түүнийг хүүхэд хулгай хийсэн гэж буруутгаж болох байсан. Гэвч тэр бол гэгээнтэн, тийм учраас түүний бүх юм бүтээд байна. Ёстой нээрэн шүү, гэгээнтэн! Тийм залуухан, тийм гоё, гэтэл хамаг амьдралаа бусдад зориулчихсан!

– Байз, байз! Юун үнэмлэх вэ, би ойлгохгүй байна?

– Алс Дорнод руу үнэмлэхгүй бол болохгүй. Макс Варя, хүү хоёрт үнэмлэх ирүүлэх ёстой байсан юм. Тэгээд тэр үнэмлэхийг ирж явах хооронд Ваня бараг бүтэн сар танай ээж, тэр хоёр дээр байсан. Софья Александровна бас хүүг минь асралцсан, ээж чинь Варягийн төлөө ч юу ч хийхэд бэлэн байсан, Варя бас ээжид чинь туслаж байсан шүү дээ, чамайг шоронд байхад эргэлт авч явдаг, нөгөө аймшигт дугаарт зогсдог байсан. Чи энэ тухай мэдэх үү?

– Мэдэлгүй яахав.

– Нина, Макс хоёр Ваняг Варягийн хүү л гэж бодсон байх.

– Би түүнийг нэг бильярдчинтай сууж байсан гэж сонссон шиг ч?

– Тийм. Мангуу явдал. Арван долоотой байсан. Шарок бид хоёрын амраглал намайг чимж байна гэж үү? Гэтэл би Варягаас ахмад байсан шүү дээ. Бид бүгдээрээ л алдаж эндэх юм, тэр алдаа эндэл л бидэнд ухаан суухад маань тус болж байна.

Лена гэнэт инээмсэглэсэнээ, Саша руу духайн харав.

– Ингэхэд, Саша, түүний гэрлэсэнд чи зарим талаар буруутай, мэдээж, дам утгаар.

– Яаж тэр билээ?

– Чамайг Казанийн буудлаас цөллөгт явуулсан, нэг даргатай хоёр хянагч дагаж явсан.

– Зүйтэй.

– Чи хууз сахалтай байсан, чемодан барьж явсан.

– Тэгсэн.

– За тэгвэл, яг тэгэхэд чинь цэргийн сургууль төгсөгчид, тэдний хамт Макс өөр зам дээрээс Алс Дорнод руу явцгааж байсан юм байна. Максыег Нина, Варя хоёр үдэж өгч. Варя чамайг олж харсан, цонхигор царайтай, өтгөн хар бахалтай байхыг чинь харсан. Амьдалдаа анх удаа айхтар цочирдсон гэж Варя надад ярьсан. Чи харгалзагч нарын дунд дуулгавартай явж байх шиг, цөллөгт дуулгавартай явж байх шиг түүнд санагдсан гэнэ. Тэгэхэд тэр чинь арван долоотой байсан, Саша, чи гомдохын хэрэггүй. Чи тэдэнд өөрийгөө доромжлуулахыг зөвшөөрсөн юм шиг түүнд санагдсан, чи эсэргүүцэл үзүүлэх ёстой байж, чамайг хүлж авч явах ёстой байж... Тэгж л цочирдсон гэж байгаа. Тэгээд өөрөө тэгж аж төрөхгүй, дуулгавартай боол болохгүй гэж шийдэж. Тэгтэл хаана ч ажил хийдэггүй, ямар нэг юм зохион бүтээдэг, их мөнгө олдог, төрөөс хараат бус нэг хүн олдож. мань Варя ч хараат бус байхын тулд түүнтэй суучихаж. Гэхдээ энэ нь шал худлаа, цаадах нь ердөө мөрийтэй тоглоомчин байсныг дорхноо ойлгоод, хөөж явуулсан гэж байгаа. Хөөх хөөхдөө нэлээд эгзэгтэй байдалд.

– Тэр нь Варяг алах гэсэн ч юм шиг?

– Өө, чи мэдэх юм уу? Би энэ тухай чамд дэмий ярьсан болж байна.

– Үгүй ээ, үгүй, би зөвхөн тэр сүүлчийн хэсгийг нь л мэднэ. Варя түүнийг хөөж явуулсан, цаадах нь ална гэж занасан. Энэ тухай ээж маань галт тэрэгний буудал дээр уулзах төдий болохдоо хэлсэн юм. Бусад бүх юмыг би анх удаа сонсож байна. Наадах чинь их сонин байна, чи ярь л даа, гайгүй.

– Энэ явдлаас Варя, хараат бус байдлыг хэн нэгэн өгдөггүй, аливаа юмыг сөрж сайн үйл хийх чадвартай бол хүн өөрөө хараат бус болдог гэдгийг ойлгосон. Одоо яг тэгж л амьдарч байгаа. Чамд гэж хэлэхэд, хэрэв Варя байгаагүй бол, би миний толгой дээр буусан тэр их лайг тэсч давж чадахгүй байсан. Варя л надад: “Цөлөх хотыг чинь асуувал Уфа гэж хэл: тэнд Саша байгаа. түүнийг заавал олоорой, өөрөө авагч гээд ил захидал биччих, мань хүн дорхноо мэдээ өгнө” гэж хэлсэн юм.

Ээ тэнгэр минь! Варя түүнийг мартдаггүй байх нь...

– Чи тэгээд яагаад надад ил захидал биччихээгүй юм?

– Саша минь, чиний байдал тэртэй тэргүй төвөгтэй байгаа, чамд дараа болохыг хүсээгүй юм.

Плевицкая юуг ч улайхгүй, элдвээр үнэн худлаа яриад байв. Хэдий тийм ч олон баримт, түүнээс гадна Скоблины алга болчихсон явдал ч түүнийг илчлээд байгаа билээ. Шүүх хурлыг бүх хэвлэл мэдээлж байв. Шарок нэг ч сонин алгасахгүй үзнэ, бүх сонин Францын засгийн газар большевикуудыг ивээж байна, цагдаагийн газар Миллерийг хулгайлагчдад ул мөрөө баллахад нь тусалсан энэ тэр гэж буруутгалаа. Гэвч мөрдлөг ч, шүүх ч зөвлөлтийн суурин тагнуулчдаас хэнийх нь ч улбааг олсонгүй, нэг ч хүний нэр гаргасангүй. Плевицкайд хорин жилийн хүчир ажлын ял заасан, чухамдаа бүх насаар нь хорьсон гэсэн үг. Цагаачид бөөн баяр. Бурцев: “Хүчир ажлын шоронд илжирч байг” гэсэн гэж байгаа.

Гэвч ОНЦХ хэрэг дээрээ задран унажээ. Третьяков урьдын адил штабын яриаг хичээнгүйлэн бичиж авсаар байгаа ч тэдгээр нь сонирхол татах юмгүй болжээ. Штаб хэдэн долоо хоногоор эзгүйрнэ, харуулынхаа цалинг тавих ч мөнгө байхгүй.

Плевицкаяг шүүж байх үед, Шарок одоо л яг Вика Марасевичтэй холбоо барьдаг цаг гэж шийджээ. Вика Озуар-ле-Ферьерт, Плевицкая дээр очсон удаатай, энэ бяцхан хотын нэрийг сонин хэвлэлээр элдэв долоон янзаар шуугиж байгаа билээ. Вика айчихсан байгаа, бүр айлгачих юм бол буугаад өгнө. Одоохондоо түүний барим тавим хэрэгцээ алга, гэхдээ хэрэг болох мөч хүрээд ирж мэднэ. Гэхдээ тэр мөч нь ирэх үед Вика учрыг мэдчихсэн байна, өөрийг нь сүрдүүлэн өдөөн хатгаж байна гэчихнэ, түүний занг мань хүн мэднэ. Москвад тэднээс бултаж дөнгөсөн юм чинь, энд тэр тусмаа дөнгөнө. Харин одоо бол сэтгэлээр унасан, шалдаа буусан байгаа, Плевицкаяг шүүх хурал үргэлжилж байгаа юм чинь тэр муу хаашаа ч зайлаад явчихгүй.

Шарок “Сухов” гэдэг нууц нэртэй ажилтанд Викатай явуулах ажилбарыг даалгав. Өөрөө бол ажил хэрэг шаардсан үед түүнтэй уулзана. “Сухов” дэргэдээс нь Вика руу утасдаж, ахаас нь захиа авчирсан, аль нэг музейд, жишээ нь Луврт, уулзвал хамгийн дээр гэж хэлэв. Өөрийнх нь хувьд уулзаж болох ганц өдөр нь маргааш, үдээс өмнө бол зүгээр байна, яг хэдэн цаг гэдгийг Викаг хэл гэжээ. Уул нь захиаг шуудангаар явуулчихаж болно, дотор нь гойдын юм байхгүй гэж Вадим хэлсэн, харин гол юмыг амаар уламжлах ёстой.

Вика чимээгүй байзнаснаа,

– Уучлаарай, таныг хэн гэдэг вэ? гэж асуув.

– Петр Александрович.

– Петр Александрович гуай, тэнд ямар нэг юм болоо юу, та хэлж болох уу?

Шарокоос маш нарийн заавар авсан “Сухов”,

– Виктория Андреевна, та намайг хэцүү байдалд оруулж байна. Энэ бол утасны яриа биш, Москва маягаар ярьж байгааг минь уучлаарай. Бусад асуудлын дотор өвийн асуудал ч байгаа. Эцгийн тань нас барсантай холбогдуулан, энэ далимд, танд чин сэтгэлийн эмгэнэл илэрхийлье гэв.

Гэтэл Вика дуугардаггүй. Шарок “Сухов”-т дохио өгөхөд цаадахь нь,

– Танд надтай уулзах хүсэл алга, надад ч бас тэгнэ гэж зүтгэх шалтгаан алга. Харин ч надад л амар юм болох нь. Вадим өөр л арга зам хайна биз. Хоёулаа баяртай гээ...

– Үгүй, үгүй, байзнаарай хэмээн Вика үгийг нь тасдав. – Яаж уулзвал илүү эвтэй вэ гэж л би бодож байна. Арван хоёр цагт, Луврын кассны хавьд гэвэл танд тохиромжтой юу?

– Тохиромжтой.

– Би яаж таныг таних вэ?

– Би танайд, Вадим дээр очиж байсан, тийм учраас би таныг сайн санаж байна. Та ч намайг эргэн санаж магадгүй. Би ганцаараа очно, таныг ч бас тэгнэ байх гэж найдаж байна.

Маргааш нь Шарок, “Сухов” хоёр арван хоёр дөхүүлээд Лувр руу машинаар очив. Вика кассны орчмоор нааш цааш холхиж харагдана. Шарок түүнийг “Сухов”-т зааж өгөв. Вика хэн нэгнийг дагуулж ирээгүй байгаа хэмээн тэр хоёр хэдэн минут музейн хавийн хүмүүсийг ажиглав. Чухамдаа “Сухов” ажиглаж, Шарок Викагаар нүд хужирлан, тэдний чинээлэг байр, тэднийхээр орж гардаг алдарт хүмүүсийг дурсан санаж суув. Вика Москвад ч дажгүй харагддаг байсан, нүд унахаар хүүхэн, яриан байхгүй.

“Сүүл” алга гэдгийг сайтар мэдэж аваад, “Сухов” Вика руу очлоо. Мэнд усаа мэдэлцээд музей рүү орцгоов. Шарок тэдний араас орж, өргөн шатаар өгсөн, танхимд оров. Вика, “Сухов” хоёр вандан сандал дээр сууцгаалаа. Шарок зураг харж буй дүр эсгэн, хана хавиар холхив.

Эцэг нь нас барсан тухай Викад Нелли Владимирова дуулгасан, Шарль бас эмгэнэлийн бичигтэй “Известия” сонин авчирч өгсөн. Вадим ганц үг ганхийгээгүй. Вика ч түүний амьдралыг эс сонирхоно. Өвийн асуудал?! Ээжийнх нь үнэт эдлэл хэзээ ч охиных нь байсан, одоо ч өөрт нь байгаа. Вадим эцгээс нь үлдсэн юмнаас түүнд хувь өгөх гээ юм болов уу? Тэгэх ёс байхгүй. Хорголоо тоолсон бирд юм чинь. Ер нь ч тэрээр зөвлөлтийнхнээс хэнийг ч харах дургүй байгаа билээ. Тэгсэн хэрнээ уулзахыг зөвшөөрсөн. Юу гээчийг хэн мэдэх билээ! Эцгийнх нь элдэв цаасан дотроос ноцтой нэг юм гарсан ч юм бил үү? Өвөг дээдэс нь гетмануудтай хамаатан садан байсан. Европт баян хамаатан садан, тэр ч атугай, мань Вика өөрөө хувь авах эрхтэй эд хөрөнгө ч байж магадгүй. Эцэгт нь Өрнөдөд бүртгүүлсэн, гэхдээ Зөвлөлтүүд мэддэггүй, анагаах ухааны нээлт, патент байсан юм болов уу? Вадим ч өөрөө зугтахаар завдаж, ийшээ сурвалжлагчаар ирээд үлдчих санаатай байж ч магадгүй, Зөвлөлтөд ямар аймшиг болж байгаа билээ дээ! Энд өөрт нь Вадим шиг хэрэггүй хүн байхгүй, ямар ч байсан толгой дээрээ гаргахгүй, харин патент юм уу, эд хөрөнгө байгаа бол тэдгээрийг Вадимгүйгээр авах арга байхгүй, мань хүн ч бас өв залгамжлагч. Товчдоо хуу мэдэж авах хэрэгтэй байна.

тэрээр энэ Петр Александровичийг ерөөсөө эс санах аж. Турьгүй, бараг туранхай залуу. Даруухан хувцастай. Инээмсэглээд байна. Пиджакныхаа халааснаас дугтуй гаргаж, дотроос нь нэг цаас сугалаад, гараасаа тавилгүй Викад харуулав.

– Виктория Андреевна, энэ баримт бичгийг та таних уу?

Вика тэр цаасыг тогтож харангуут хамаг бие нь хүйт даагаад явчихав. Тэр цаас нь Лубянкад түүний тухайн үедээ хамтран ажиллах тухай авсан үүрэг аж. Хараал идэх нь таарсан өнгөрсөн явдал, хараал идэх нь таарсан улс орон! Петр Александрович үүргийг нь эвхэж халааслаад,

– За яаж байна, Виктория Андреевна, санаж байгаа биз дээ? гэж асуултаа давгав.

Эд муусайн түүнд юу хийж чадах юм бэ? Энд чинь Москва биш! Цагдаа дуудаад л, энэ муу зөвлөлтийн тагнуулыг тушаачихна! Нэг муу хуурамч цаасаар сүрдүүлж өдөөн хатгах юм гэнэ. Энэ цаас юуны өмнө энийг өөрийг нь илчлэнэ.

– Үгүй, би наад бичгийг чинь мэдэхгүй. Хоёулаа цагдаад очиж, тэнд учраа олох юм уу?

– Бидэнд цагдаа хэрэггүй ээ, Виктория Андреевна гээд Петр Александрович инээмсэглэв. – Тэгэх юм бол баахан сурвалжлагч шавчихна, энэ баримтыг сонинд нийтэлчихнэ, бичгийн хэлбэрийн шинжээчийн дүгнэлтийг няцаахад танд хэцүү байх болно, Плевицкая хатагтайтай холбоотой байснаа, Озуар-ле-Ферьерт очиж байснаа тайлбарлахад хэцүү байх болно. Энэ бүхэн чинь олон нийтийн сонирхлыг айхтар татна. Хатагтай Плевицкаяг илчилчихсэн, тантай, ДЯАК-ын ажилтантай холбоотой байсан нь түүний хаягаар шинэ яллах зүйл нэмнэ, нэмэрт нь таныг ч бас илчлэнэ. Цагдаа руу явахаас урьдаар яггүй сайн бодох хэрэгтэй.

Энэ муухай золигийн сайхан инээмсэглэж байгаад хэлсэн үг хоосон сүрдүүлэг биш: өөрийнх нь ч амьдралыг, Шарлийн ч амьдралыг үрэн таран хийнэ. Эд муусайн Москвад Лубянкад тэгдэг шигээ хилийн чанадад ч ял зэмгүй хэргээ тарьж байдаг юм байна! Гэгээн цагаан өдөр генерал Миллерийг, түүнээс өмнө генерал Кутеповыг хулгайлсан, эх орондоо буцаагүй Игнатий Райссыг алсан. Скоблин бол генерал, Плевицкая бол алдарт дуучин, гэтэл тэд хүртэл эд нарын төлөө ажиллаж байж гээд бод доо!

– Би танд төвөг удах бодолгүй байна. Бид танаас Францын хуульд харшлахгүй, ойр зуурханы тус хүсч магадгүй. Бид танд нэг ч удаа төвөг удаагүй, тийм шаардлага байсангүй. Плевицкаягийн хэргээс болж шаардлага гарлаа. Та тэднийд очиж байсан, тэгэхээр та нарын юун тухай ярилцаж байсныг л мэдмээр байгаа юм.

– Гойдын юм юу ч байхгүй! Надежда Васильевна амьдралынхаа тухай ярина, заримдаа дуулна, Оросыг дурсан санана, их сүсэгтэй хүн, надад сүмээ үзүүлсэн. түүнийг шүүж болсонд би маш их гайхсан, цочирдсон!

– Маш сайн байна! Саяныхыгаа л биччих. Дараачийн пүрэв гаригт яг энэ цагтаа, энэ газраа аваад ирээрэй. Элдэв мунхаг юм хийв ээ, урьдчилан анхааруулья, Виктория Андреевна. Нэг л гэнэн алхам хийлээ бол, тэр даруй таны зураг, таны үүрэг, Плевицкая та хоёрын уулзсан сар өдөр энэ тэр бүх сонинд гарна. Таныг хэрсүү байх байх гэж найдаж байна.

Энэ уулзалтын дараа Шарок “Сухов”-т ингэж тушаав:

– Зугуухан чангаагаад бай, юу л авчрана, тэр нь болж явчихна. Уяаг нь уртхан байлга. Музей, үзэсгэлэн мэтийн, гагцхүү олон шийтийн газар уулзаж бай.

Удалгүй Эйтингон ирэв. Викагийн хувьд явуулж буй ажилбарыг сайшаахын хамт болгоомжтой ажиллахыг зөвлөв. Баян хүмүүс, түүнд мөнгөний хэрэгцээ гарахгүй, үзэл санааны сэдлэг байхгүй. Тэгэхээр зөвхөн айдас, энэ бол тухайн тохиолдолд найдваргүй сэдэл. тэрээр одоо Викаг сонирхохгүй байгаа, Шарокт испаничуудыг анхаарах чиглэл өгөв. Тэднийг Мексик түү илгээж, тэнд хорлон сүйтгэх ажиллагаа явуулах томоохон бүлгийг эмхлэн, ёстой мөнгө хайрлахгүй, далайцтай ажиллаж байгаа билээ.

Тохирсон ёсоор “Сухов” долоо хоногийн дараа Шарокоор хань хийсээр Лувр руу давхиж хүрэв. Танхим руу орцгоов. Вика вандан сандал дээр хүлээгээд сууж байв. Гэвч “Сухов” түүн рүү очилгүй, гэхдээ түүнийг хараанаасаа гаргалгүй, Шарокийн хамт зураг үзэж явсаар дараагийн танхим руу оров. “Сухов” сахал, бахал нааж гадаа төрхөө өөрчилсөн аж. Нэг их олон хүн байсангүй, Шарок, тэр хоёр бүтэн цаг танхимаас гарахгүй байгаа, хэн гэдгийг нь тааж цөхөх юмгүй хоёр этгээдийг анзаарчээ. Тэгж байтал сайхь хоёр этгээд гарч, Вика ч араас нь яваад өгөв.

Вика нөхөртөө хамаг үнэнээ хэлж, цаадахь нь сөрөг тагнуулын газартайгаа холбоо бариад, Викаг ашиглан зөвлөлтийн тагнуулын мөрөөр орохыг санал болгож, тэгснийх нь хариуд хүүхний Москвад зүггүйтэж байсныг нь уучлана гээ биз гэсэн таамаг Эйтингон хэлэв. Тэгээд,

– түүнийг одоохондоо битгий хөнд, хэрэгцээ алга байна. Цаг нь болохоор бодоцгоогоорой гэжээ.

Шарок Эйтингон, Морнар, Испанийн хүмүүс энэ тэртэй удаа дараа уулзсанаар, хийх гэж буй ажилбарын үндсэн оролцогчдын тухайд төсөөлөлтэй болжээ. Ажилбарыг Москвад Судоплатов, энд Эйтингон удирдаж байна. Эустасия Мария Каридада дель Рио гэдэг эмэгтэй бол Эйтингоны нууц амраг төдийгүй туслах нь. Баян куба хүний охин, Барселонд суудаг Меркадер гэдэг сурвалжит испанитай ханилж, таван хүүхэдтэй болоод салж, Парист хүүхдүүдтэйгээ аж төрж байснаа Барселонд эргэж ирж, коммунист намд элссэнийг Эйтингон өөртөө урвуулсан юмсанж. Хүүхдүүд нь түүний нөлөөнд байдаг, тэднийх нь нэг Рамон Меркадер одоо энэ Жак Морнар болчихсон аж.

Ежов дотоод явдлын ардын комиссарын албан тушаалаас чөлөөлөгдсөн тухай албан ёсны мэдээ ирлээ. Ингээд болох юм болчихлоо. Ежовыг нэгэнт талийгаач болсон гэж үзэж болно. түүнийг долоо хоногийн дараа юу, нэг хоёр сарын дараа юу, чухам хэзээ шоронд хийж, буудан алах нь ямар ч ач холбогдолгүй асуудал. Оронд нь Берияг томилжээ. Шинэ шүүр яаж шүүрдэх бол? Шарок энэ бүхний тухай Эйтингонтой ярилцмаар байсан нь мэдээж ч, санаа зовж байгаагаа харуулах хэрэг огт байхгүй хэмээн зүрхэлсэнгүй. Хүмүүсийг нааш цааш болгож таарна, гэхдээ тэдний хэлтэс нэрвэгдэх нь юу л бол, “эзний” хувьд гол зорилго бол Мексик, түүнийг бэлтгэж байгаа хүмүүст гар хүрэхгүй. Харин даалгавар биелүүлэхгүй бол хөндөнө. Удаан ч гэсэн бүх юм дажгүй явж байна. Сильвия Америк руугаа буцсан. Меркадер наймааны ажлаар шалтаглан одоохондоо Парист үлдсэн. Үнэн хэрэгтээ бол Эйтингон илүү найдвартай паспортоор түүнийхийг солихоор шийджээ. Тэгээд 1905 оны долдугаар сарын 13-нд Югославт төрсөн, 1929 онд Канадын харьяат болсон Франк Жексон гэгч болгожээ.

Наймдугаар сард бүх юм бэлэн болов. Рамон Меркадер, бас Франк Жексон, бас Жак Морнар гэгч маань эцсийн бүлэгт Америк руу явах боломжтой боллоо. Тэнд түүнийг Сильвия хүлээж байгаа.

Хамгаалагч, үйлчлэгч нараар бараа хийсэн Германы олон хүнтэй төлөөлөгч дөрвөн мотортой хоёр “кондор” онгоцоор Берлинээс нисэв. Нэг нь фюрерийн хувийн онгоц, түүгээр Риббентроп нислээ. Наймдугаар сарын 23-ны үд дунд Москвад газардав. Риббентроп үдийн хоол хам хум идээд, Кремль рүү яаравчлав. Молотовтой 15.30-д хэлэлцээ хийх товгой. Орой нь Сталинтай уулзана. Гэтэл Молотовын өрөөнд ортол тэнд Сталин бас байж байв.

Энэ бол түүний нүүдэл, тэрээр Гитлерийн сайдыг шууд нам авахаар шийджээ. Гэхдээ энгийн, найрсаг, дотносог байдалтай байв. ТЭР бол дипломат биш, ТЭР бол энд эзэн, шүүгч. Маргааныг ганц өгүүлбэрээр, ганц үгээрээ шийдэж чадна. мань хүн буйдан сандалд суугаад Молотов, Риббентроп, хэлмэрч Павлов гурвыг анхааралтай сонсож байв. Гэрээний Зөвлөлтийн төсөл товчхон: ЗСБНХУ, Герман хоёр бие биенийхээ хувьд хүчирхийлэл, түрэмгийлэл, довтолгооноос түдгэлзэнэ. Хэрэв нэг этгээд нь гуравдагч улсын байлдааны бай болвол, нөгөө этгээд нь тэр улсыг үл дэмжинэ. Хоёр этгээд маргааныг гагцхүү эвийн аргаар шийдвэрлэнэ. Гэрээг таван жилийн хугацаагаар байгуулна, соёрхон баталсны дараа хүчин төгөлдөр болно.

Риббентроп: гэрээг тав биш арван жилээр байгуулах, гарын үсэг зурмагц хүчин төгөлдөр болохоор засвар оруулахыг санал болгов. Яарцгааж байна, тэгээд улам аятайхан болгохыг зорьж байна. За яахав, зөвшөөрч болно, зөвлөлтийн ард түмэн үүнийг дэмжинэ: гэрээ нэн даруй хүчин төгөлдөр болж байгаа бол энх тайван нэн даруй хүчин төгөлдөр болж байна гэсэн үг.

Нууц протоколынхоо асуудал руу орцгоолоо. Риббентроп дөрөв нугалсан цаас гаргаад хэлмэрч Хильгерт өгөв. Хильгер түүнийг зүйл дараалан уншлаа. Риббентроп Сталинаас хараа салгасангүй. Гэвч Сталины царайнаас юу ч олж мэдэхийн арга алга. тэрээр нүдээ таглаад, Зүүн Европт хоёр улсын ашиг сонирхлыг зааглах тухай протоколыг оросоор уншиж байгаа Хильгерийг сонсож байна... Гитлер түүнд Балт орчим руу нэвтрэх замыг нээж байна, Польшийн талыг өгч байна, харин Польшийн өөрийнх нь оршин тогтнох тухай асуудлыг тэд цаашид шийднэ. түүнд Германтай нийлсэн хилтэй байх, эсвэл хооронд нь Польшийн ямар нэг хэлтэрхий үлдээх хоёрын аль нь ашигтайг тэрээр дахин бодох ёстой.

– Ноён Сталин, ингээд гүйцлээ гээд Хильгер цаасыг ширээн дээр тавив.

Сталин зугуухан, бас хэлмэрчид орчуулах боломж олгон азнас азнасхийн ярив.

– Протокол үндсэндээ хүлээн авч болохуйц байна гэж би бодож байна. Бессараби дахь Зөвлөлт Холбоот Улсын ашиг сонирхлыг дурдах нь ач тустай болно. Бессараби хэзээнээс нааш Оросын бүрэлдэхүүнд байсан, түүнийг Румын 1919 онд эзлэн авсныг нийтээр мэднэ.

Риббентроп орчуулгыг сонсоод,

– Ноён Сталин, би таныг ойлголоо. Би ноён Гитлерийн зөвшөөрлийг нэн даруй асууя. Хариу түргэн ирнэ, эерэг хариу ирнэ гэж найдаж байна.

Хариу хоёр цагийн дараа ирлээ.

“Тийм ээ, зөвшөөрч байна. Гитлер”.

Баримт бичигт шөнө дунд гарын үсэг зурахаар болов.

Сталин гарын үсэг зурах ёслолд жанжин штабын дарга Шапошниковыг урь гэж тушаажээ. Хуучин хаант засгийн армийн хурандаа хүн байлцах нь Германы цэргийн дээд тушаалтныхны сэтгэлд нийцнэ. тэрээр хэдхэн урвагчийг устгасан, офицерын бүрэлдэхүүний үндсэн хэсэг нь түүнийг дэмжиж байгаа гэдгийг мэдэж авцгааг.

Молотов, Риббентроп нар гэрээ, протокол хоёрт гарын үсэг зурав. Тогтсон жаяг ёсоор хавтсаа солилцон, гар барьцгаалаа. Риббентроп түүнийг Гитлертэй утсаар холбож өгөхийг хүсэв. Урд өдөр нь шууд холбоо тоногдсон аж. Өөрөөрөө бахархаж, догдолсон Риббентроп бүх баримт бичигт гарын үсэг зурсан, ирсэн ажил нь маш амжилттай болсон тухай Гитлерт баяртай илтгэв. Риббентроп Гитлертэй ярьж байхдаа, Молотовын сандал дээр андуураад суучихав.

“Хэт баярласнаасаа болоод бүр мангуурчихаж” гэж Сталин боджээ.

Дарс, зууш ширээн дээр тавилсан өрөө рүү орцгоов. Тэнд сурвалжлагчид, гэрэл зурагчид тэднийг хүлээж байжээ. Бүгдээрээ зогсоогоороо идэж ууцгаав. Сталин хананы дэргэдэх буйдан сандалд суугаад, Риббентропыг хажуудаа суухыг урив. Риббентропын дэргэд герман хэлмэрч Хильгер, Сталины дэргэд орос хэлмэрч Павлов нар байраа эзэлцгээв.

– Ноён Риббентроп зөвлөлт-японы харилцааг юу гэж үзэж байгааг мэдэхэд сонин байна? гэж Сталин асуув.

Риббентроп орчуулгыг сонсоод, үнэн сэтгэлийн тэмдэг болгож, гараараа зүрхэн тус дарав.

– Ноён Сталин, герман-японы найрамдал Зөвлөлт Холбоот Улсын эсрэг хэрхэвч чиглээгүйг танд батлан хэлье. Түүгээр ч барахгүй, ноён Сталин, бид Зөвлөлт Холбоот Улс, Япон хоёрын санал зөрөлдөөнтэй асуудлыг зохицуулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулах бололцоотой. Би энэ чиглэлээр эрчимтэй ажиллахад бэлэн байна.

Алс Дорнодоос ирсэн мэдээг хэдэн цагийн өмнө түүнд гардуулсан юм. Халх голын районд зөвлөлтийн цэргийн давшилт амжилттай өрнөж, Японы армийн үндсэн хүч бүрэн бүслэгджээ. Риббентроп энэ тухай, мэдээж, мэдэхгүй.

– Зөвлөлт Холбоот Улс дайнаас айхгүй, түүнд бэлэн байгаа. Хэрэв Япон энх тайвныг хүсч байгаа бол тэр тусмаа сайн л байна. Мэдээж, Германы тусламж ашигтай байж болно. Гэхдээ бид хэнээс ч тусламж гуйхгүй байна. Бид гагцхүү өөрийнхөө хүчинд найдаж байгаа.

– Мэдээж, тэгэлгүй яахав, ноён Сталин, таных туйлын зөв. Герман ямар ч шинэ санаачлага гаргахгүй. Би тэдэнтэй хэдэн сар ярьж байгаа юмаа л зүгээр үргэлжлүүлнэ.

Ойлгож байна шүү! Геринг түүнийг ажлын мэдлэггүй гэсэн нь дэмий үг аж.

Тэдний дэргэд гэрэл зургийн аппараттай хүн хүрээд ирэв. Риббентроп,

– Ноён Сталин, танд ноён Гитлерийн анд нөхөр, хувийн зурагчин ноён Гофманыг танилцуулахыг болгооно уу гэж сүрхий ёсорхуу өгүүлэв.

Сталин Гофмантай гар бариад, ширээ рүү зааж инээмсэглэв.

– Ноён Риббентроп бид хоёр ширээ рүү очихоороо таны эрүүл мэндийн төлөө ууцгаана.

Догдолсон гэрэл зурагчин,

– Эрхэмсэг ноёнтоон, өөрийн анд Адольф Гитлерийн чин сэтгэлийн мэндчилгээ, сайн сайхны ерөөлийг танд уламжлах нь миний хувьд их нэр төрийн хэрэг. Анд маань оросын ард түмний аугаа их жолоодогчтой биечлэн танилцахдаа нэн баяртай байх болно гэж өчив.

– Миний хувьд ч гэсэн түүнтэй танилцах нь аз завшаан байх болно гэж ноён Гитлерт уламжлахыг танаас хүсье гэж Сталин хариулав.

Дараа нь Гофман алхам ухарч аппаратаа тогтоогоод, Сталин, Риббентроп хоёрын зургийг авч талархал илэрхийлээд ширээ рүү зүглэв.

– Туркийн тухайд юу гэж бодож байна? гэж Сталин асуув. – Турк Зөвлөлт Холбоот Улстай хиллэдэг, Турк Босфор, Дарданеллийн хоолойг эзэмшдэг, тэр нь Зөвлөлт Холбоот Улсын Хар тэнгисийн флотын Газар Дундын тэнгис рүү, цаашилбал, гадаад далай руу гарах гарц. Тэр хоёр хоолой бол Оросын бодлогын эртний бөгөөд хурц асуудал.

– Өө, ноён Сталин! хэмээн Риббентроп дуу алдав. – Турктэй найрсаг харилцаатай болохын тулд би бүхнийг хийж байгаа. Гэхдээ түркүүдтэй тохиролцох маш хэцүү, ноён Сталин.

– Тийм шүү, түркүүд дандаа гуйвж дайвж байдаг юм гэж Сталин ам нийлэв.

– Ноён Сталин, энэ бол ойлгомжтой. Англи Туркт Германы талаар сөрөг сурталчилгаа явуулахад таван сая фунт стерлинг зарцуулсан хэмээн Риббентроп бас ам дагуулав.

Сталин жуумалзав.

– Английн ноёлогч баячууд бүх юмыг зардаг, худалдаж авдаг гэж бүрэн итгэж байгаа. Жишээ нь, тэдний цэргийн төлөөлөгчид манайд ирлээ л дээ, тэгээд арав хоног чалчсан. Тэдний үнэндээ юу хүсээд байгааг бид чухамдаа ойлгоогүй. Хэрэв биднийг худалдаж авч болдог байсан бол, тэд нар юу хэлэхээ мэдэх байсан байх. Гэтэл таны ойлгож байгаачлан, биднийг даанч худалдаж авч болохгүй.

– Ноён Сталин, өршөөгөөрэй хэмээн Риббентроп толгой дохилж, – Англи сулхан гэдгийг би танд хэлж болох байна, батлан хэлж байна шүү, ноён Сталин. Би Англид элчин сайд байсан, Английн сулхан, тэгээд дэлхийд ноёрхох гэсэн дээгүүр санаархлаа бусад улсаар дэмжүүлэхийг хүсч байгаа гэдгийг мэднэ гэв.

Хоёр хоолойн асуудлаас зайлсхийж, Англи руу үсэрч орлоо. За яахав. Энэ асуудлын шийдлээс Гитлер хаашаа ч зайлахгүй — ЗСБНХУ Хар тэнгис дээр ноёрхож байх ёстой. Хэсэг хугацаа өнгөрсний дараа тэрээр одоо Гитлерийн өгөх дургүй байгаа хоёр хоолойг ч, бас өөр ч их юмыг шаардах болно.

– Би тантай санал нийлж байна гээд Сталин тийнхүү хүлээн зөвшөөрч байгааг нь Риббентроп үнэлэг хэмээн дуугүй болзгносоо, – Англи бусад улсын тэнэгийн харгайгаар л дэлхийд ноёрхож байна. Ердөө хэдхэн зуун англи хүн Энэтхэгийг захирч байна, энэ инээдтэй биш гэж үү? Гэхдээ тэд дайныг шургуу явуулна, улс орнуудын хоорондын зөрчлийг овжин ашиглана. Нэмэрт нь Английн холбоотон Франц тооцооноос хасч болохгүй армитай... Молотовоос асууя л даа.

тэрээр Молотовыг нааш ир гэж дохив.

Молотов тавгаа ширээн дээр тавиад хүрч ирлээ.

– Ноён Риббентроп бид хоёр Францын цэргийн хүч чадлын тухай асуудлыг ярилцаж байна. Та юу гэж бодож байна? гэж Сталин асуув.

– Франц анхаарч үзвэл зохих армитай гэж би бодож байна.

– За тэр дээ! гэж Сталин Риббентропт хэлэв.

– Ноён Сталин, танд, бас ноён Молотов, танд илүү баталгаатай мэдээ байгаа байж магадгүй. Гэхдээ “Өрнөдийн далан” “Мажиногийн шугамнаас” тав дахин хүчтэй гэдгийг бодолцоорой, ноёдоо гэж хариулав.

Сталин дотроо жуумалзав. Молотов ч бас тэгж. Германы “Өрнөдийн далан” гэдэг нь Люксембургээс Швейцарийн хил хүртлэх тархай бутархай бэхэлгээ байгаа, нэгдмэл хамгаалалтын шугамын хувьд зөвхөн цаасан дээр байгааг тэр хоёр маш сайн мэдэж байгаа билээ. Риббентроп ч бас үүнийг мэдэлгүй яахав. Хэдий тийм ч хэлснийгээ итгэлтэй болгохын тулд ихэмсэг байдлаар,

– Хэрэвзаяа Франц Германтай байлдах гэж оролдвол ялагдах нь тов тодорхой. Германд холбоотон бий... гэж нэмж хэлэв.

– Коминтерний эсрэг гэрээний юу? гэж Молотов ёгтлон асуув.

Риббентроп боссоноо буцаж сууж, сүрхий догдлон ярьж эхлэв:

– Ноён Сталин, ноён Молотов, ноёд оо. Би энэ асуудлыг бүрэн тодорхой болгохыг хүсч байна. Коминтерний эсрэг гэрээ Зөвлөлт Холбоот Улсын эсрэг хэрхэвч чиглээгүй, тэр гэрээ гагцхүү өрнөдийн ардчилсан улсуудын эсрэг чиглэсэн гэдгийг би маш тодорхой, маш хатуу мэдэгдэхийг хүсч байна.

– Коминтерний эсрэг гэрээ зөвхөн жижигхэн англи наймаачдыг л айхтар айлгасан. Энэ гэрээ өөр хэнийг ч айлгаж чадаагүй гэж Сталин өгүүлэв.

Өөрийнхөө холбооны нэрийг болгоомжтой сонгож байх хэрэгтэйг Гитлер ойлгож аваг. Ямар ч коминтерний эсрэг гэрээнээс тэрээр айхгүй.

Риббентроп дооглосныг ойлгосонгүй, эсвэл ойлгоогүй царайлав...

– Чухам аа чухам, ноён Сталин, яг тийм. Энэ гэрээ зөвлөлтийн ард түмнийг айлгаж чадах байсан гэж би ч бас бодохгүй байна. Зөвлөлтийн хэвлэлийг уншаад би энэ тухай гадарлаж байсан юм. Германууд энэ бүхнийг бузгай ойлгож байгаа. Юу л даа, ноён Сталин, хурц ухаанаараа зартай берлинчүүдийн дунд “Сталин коминтерний эсрэг гэрээнд нэгдэнэ ээ гайгүй” гэсэн наргиа үг хэдэн сарын турш явж байгаа.

Сталин ярвайв. Энэ муу герман хошин шогийн мэдрэмжгүй юм байна. Энэ тухайд Герингийн зөв байж.

– Берлинчүүд мундаг наргианчид байх нь гэж Сталин өгүүлээд, – Тэгвэл герман түмэн Герман, Зөвлөлт Холбоот Улс хоёрын харилцааг зохицуулахад яаж хандаж байна? гэв.

– Германы ард түмний бүх давхарга үүнд баяр хүргэж байгаа, ноён Сталин. Бидэнд гагцхүү Английн далд явуулга саад болж байгааг хамгийн жирийн хүмүүс ч мэднэ.

– Жирийн хүмүүс дандаа энх тайвныг хүсч байдаг гэж Сталин өгүүлэв.

– Тийм ээ, германы ард түмэн энх тайвныг хүсч байна, гэтэл, нөгөө талаас, Польшт бухимдаад бүгд толгой дараалан байлдахад бэлэн байгаа. Германы ард түмэн Польшийн өдөөн хатгалгыг цаашид тэсвэрлэж чадахгүй.

Сталин Германы Польштой хийх дайны тухай ярих бодолгүй байсан учир орчуулгыг гүйцээж сонсолгүй босч, гараараа дохин Риббентропыг ширээ рүү урив.

Үйлчлэгч оргилуун дарс хундагалав. Сталин хундагаа өргөхөд бүгд чимээгүй болцгоов.

– Германы ард түмэн жолоодогчдоо хичнээн хайртайг би мэднэ, тийм учраас би түүний эрүүл мэндийн төлөө уумаар байна гэж Сталин хэлэв.

Бүгд Гитлерийн төлөө ууцгаав. Энэ агшинд Сталины нэгэнт таних болсон герман зурагчин аппаратаа шурдхийлгэв. Сталин түүнийг дуудаж, хоосон хундага руу дохиход, зурагчин оргилуун дарс яаран хийж Сталинтай тулгав.

Сталин хэлмэрч Павлов руу эргэн,

– Тийм зургийг нийтлэх хэрэггүй гэж энүүнд хэл. Тийм зургийг зөвлөлтийн болон германы хүмүүс буруу ойлгож мэднэ. Германы болон зөвлөлтийн хүмүүс биднийг энд энх тайвныг хангаж байгаа бус, архидан согтуурч байна гэж бодож мэднэ гэв.

– Уучлаарай, ноён Сталин, уучлаарай, та туйлын зөв, би одоо аппаратаа онгойлгоод хальсаа өгчихье хэмээн зурагчин сандрав.

Сталин гараа дохин зурагчинг болиулав.

– Тэгэх хэрэггүй! Би түүнд итгэж байна. Надад түүний үг хангалттай гэж түүнд хэл.

Сталин зурагчинд дэмий итгэжээ. Гитлерийн нэгэн адил зурагчин ч бас түүнийг мэхэлжээ. Гитлерийн эрүүл мэндийн төлөө Сталины ууж байгаа зураг хэсэг хугацааны дараа германы хэвлэлд, дараа нь дэлхий нийтийн хэвлэлд нийтлэгдсэн байна.

Молотов нөхөр Сталины төлөө хундага өргөв.

– Чухамхүү нөхөр Сталин энэ оны гуравдугаар сард хэлсэн үгээрээ манай хоёр орны улс төрийн харилцааг бүрэн өөрчилсөн. Тэр үгийг Германд зөв ойлгосон.

Молотов Сталины намын XVIII их хуралд тавьсан илтгэлийг хэлсэн хэрэг.

Молотов дараа нь Риббентропын төлөө, Германы элчин сайд Шуленбургийн төлөө, мөн герман үндэстний төлөө хундага өргөв.

Риббентропын ноён Сталины төлөө, ноён Молотовын төлөө, зөвлөлт засгийн газрын төлөө өргөсөн хундага орооцолдсон урт үг болж сунжрав.

Цонхы цаана үүрийн гэгээ туяарч, наймдугаар сарын 24-ний өглөө болов. Хүлээн авалт дууслаа.

Сталин Риббентропыг үүд хүргэж өгөөд зогтусч, хэлмэрчээр дамжуулан аажуухан, даацтай, бас өөрт нь санагдсанаар бол, сэтгэл гарган ингэж хэлэв:

– Зөвлөлт засгийн газар шинэ гэрээнд маш буурьтай хандаж байгаа гэж ноён Гитлерт уламжлаарай. Зөвлөлт Холбоот Улс өөрийн түншээс хэзээ ч урвахгүй гэж би танд чин үнэнээсээ хэлж байна.

– Ноён Сталин, миний ноён Гитлерт уламжлах хамгийн түрүүчийн үг нь саяны таны үг байх болно гэдэгт та итгэл төгс байж болно гэж Риббентроп хариулав.

Наймдугаар сарын 31-ний орой ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн ээлжит бус чуулганаар ЗСБНХУ, Германы хоорондын үл довтолцох тухай Гэрээг соёрхон батлав.

Есдүгээр сарын 1-ний үүрээр, өглөөний 4.45-д Германы арми Польшийн хилийг нэвтэрч, Варшав руу хойт, өмнө, баруун зүгээс нь хөдлөв. Дэлхийн хоёрдугаар дайн, хүн төрөлхтний түүхийн хамгийн их цус урсгасан дайн эхлэх нь тэр ээ.

Гэхдээ эхлээд энэ их хачин дайн байв. Англи, Франц хоёр Германы танкийн цуваа хоёр долоо хоногт Польшийн армийг бут ниргээд, нийт улсыг нь туулан Брестийг эзэлснийг тайван ажиглаад, нэг ч буун дуу гаргасангүй.

Өрнөд түүнийг Гитлертэй улаан нүүрээр нь тулган үлдээж байгаа юм биш биз? түүний ар худрагаар шинэ “Мюнхений хуйвалдаан” хийчихсэн юм биш биз? Тэд Гитлерийн цохилтыг Зөвлөлт Холбоот Улс руу чиглүүлэхийн тулд Польшийг золиосонд гаргасан юм биш биз? тэрээр буруу тооцоолсон юм биш байгаа? түүнийг Гитлер мэхэлсэн юм биш биз?

Есдүгээр сарын 17-нд зөвлөлтийн цэрэг Польш руу нэвтэрч, ямар ч эсэргүүцэл үзэлгүй, Риббентроптой тохирсон шугамыг хүрэв. Тэгэхээр Гитлер түүнийг мэхлээгүй байх нь. Брест болон бусад хотыг зөвлөлтийн цэрэгт шилжүүлэн өгөхөд, нөхөрсөг, дулаан уур амьсгалд болсон хамтарсан цэргийн парад хийв. Дэргэдээ тийм хөршгүй аж төрж болно.

Есдүгээр сарын 17-нд Риббентроп Москвад дахин ирлээ. Энэ удаа түүнийг Молотов өөрөө угтаж, хүндэт харуул жагсчээ. Онгоцны буудлыг эдүгээ хүрэлцээтэй тоогоор бэлтгэсэн хастай тугаар чимэглэсэн байв.

Яриа хэлэлцээ Сталины өрөөнд оройн арван цагт эхлээд үүр цайтал үргэлжилжээ. “Найрамдал ба хилийн тухай” гэрээ байгуулав. Польшийг хувааж авцгаалаа. ЗСБНХУ Балт орчмын нутгийг бүхлээр нь авав. Газрын зураг дээр шинэ, “эцэслэсэн” хилийг зурав. Сталин түүнд хөх, Риббентроп улаан харандаагаар тус тус гарын үсэг зурав. Польш маань улс гэдгээр оршин байхаа болив. Молотов: “Версалийн гэрээний энэ эрэмдэг бүтээлээс юу ч үлдэхгүй болоход германы армийн зүгээс, дараа нь Улаан Армийн зүгээс товчхон цохилт хийхэд хангалттай байлаа” гэж мэдэгдэв.

Маргааш нь Сталин Риббентропт зориулан хүлээн авалт хийв. Орой нь Их театрт “Хунт нуур” бүжгийн жүжиг үзэцгээв. Риббентроп хожим Сталинтай уулзсан энэ уулзалтынхаа тухай: “Намынхаа хуучин нөхдийн дунд байгаа юм шиг санагдах үе гарч байсан даа” гэж бичжээ.

Риббентропыг явсны дараа Зөвлөлт Холбоот Улс Эстони, Литва, Лативт цэргээ байрлуулж, усан цэргийн бааз, нисэх буудлууд байгуулав. Аравдугаар сарын 12-нд Финляндтай хэлэлцээ хийж эхлэв. Энэ яриа хэлэлцээ яаж төгсөх тухайд Сталинд эргэлзээ байсангүй: өчүүхэн Финлянд агуу их, хүчирхэг Зөвлөлт Холбоот Улстай байлдана гэхгүй биз дээ!

Бүх дэлхийн түүхэн ач холбогдолтой ийм амжилтын дэргэд Троцкийн гуагалах ямархан үнэ цэнэтэй вэ! Салахаа үзэхгүй, хорт шүлсээ үсчүүлнэ: “Кремль аль хэзээнээс Гитлертэй цэргийн хэлэлцээртэй болох гээд байсан нь одоо ил боллоо. Сталин Гитлерээс айж байна. Санаандгүй айж байгаа юм биш. Фашизм ялалтаас ялалт руу явж байна. Герман-зөвлөлтийн гэрээ бол зөвлөлтийн олигархийн амийг аврах зорилгоор Сталин фашист империализмын өмнө бууж өгсөн хэрэг мөн... Гитлер байлдааны үйл ажиллагаа явуулж байхад, Сталин тэдний хангамжийн албаны офицерийн үүргийг гүйцэтгэж байна... Цэрэг дайны аймшигтай аюул Зөвлөлт орны хаалгыг балбаж байна... Герман хоёр жилийн дараа Зөвлөлт Холбоот Улс руу довтлоно. Цаасны тасархай дээр тавьсан Риббентропын гарын үсэг цорын ганц баталгаа

болж байна”.

Сталин Троцкийн өгүүллийг өөрөөсөө холдуулж хаяв. Муу мал! Улс төрчийн хувьд нэгмөсөн сөнөсөн, ард нь хэн ч байхгүй, өөрийнх нь үр хүхэд хүртэл байхгүй, гэтэл яаж салахгүй байгааг нь хараач! Нэг завсраар шигдчихээд төлөг тавьж байна: Гитлер хоёр жилийн дараа Зөвлөлт Холбоот Улс руу довтлоно! Хаанаас ийм барим тавим төлөг тавьж байна? Дөчин нэгэн онд дэлхий шал өөр болчихно, Троцкийг өөрийг нь ч, солиотой мэргэ төлгийг нь ч мартчихна. Энэ хүний хорвоод байх тоотой хэдхэн хоног үлдсэн. түүний захирамжийг Судоплатов, Эйтингон хоёр биелүүлэхгүй байх гээд үзэг!

Хөгшин зөнөг Литвинов бас уран үг урсгаж байна. Хүн ардын өмнө дуугарахгүй хэрнээ гэртээ, эхнэрийнхээ өмнө дураараа донгосоно, гэхдээ гэрт нь сонсох төхөөрөг байгааг мэднэ, тийм учраас түүнийг нэг ч удаа нэрлээгүй, зөвхөн Молотовыг шүүмжлэнэ. Гэвч тэрээр битүүдээ хэнийг хэлээд байгааг сайн мэднэ.

Бичлэгийг шинээр бичээд түүний өмнө тавьжээ.

“Гитлер ЗСБНХУ-ын баруун хилд яг тулсан байрлал эзэллээ. Зөвлөлт Холбоот Улсын хувьд Баруун фронт бий боллоо... (Ханиаж байна.) Хэлэлцээр ЗСБНХУ-ыг гитлерийн Германтай зарчимгүй хамтын ажиллагаанд татан оруулж байна. Молотов Германтай тогтвортой харилцаа өөрөө тогтоож чадна гэж найдаж байна. Энэ бол осолтой төөрөгдөл!.. (Найтааж байна... Салхи авчихсан юм уу, хаашаа юм, годил чинь?!) Герман бол Оросын мөнхийн дайсан. Гэрээ, хэлэлцээр хоёр дэлхийн хоёрдугаар дайны замыг нээсэн”.

Литвиновыг буудан алвал зохих сон. Тэр Троцкийгоос юуны ялгаа байна? Гэхдээ түүнд одоохондоо гар хүрч болохгүй. Гитлертэй тогтоосон холбоо бэхжиж байна, тэгэхээр эрт, орой хэзээ боловч еврей нарын тухайд ямар нэг алхам хийхээс өөр үггүй болно. Мэдээж, Зөвлөлт Холбоот Улс өөрийн интернациональч мөн чанараас татгалзахгүй, тийм хөзрөө мань хүн өгөхгүй, дараа нь, эцсийн, шийдвэрлэх мөчид тэрээр энэ хөзрөө үндэсэрхсэн гитлерч ихэмсэг занд сөргүүлэн тавина. Энэ бол алс ирээдүйн хэрэг. Гэхдээ тэр ирээдүй хүрэх замд зарим нэг үзэл суртлын буулт хийхэд, еврей нарыг хазаарлах, энэ ясыг Гитлерт хаяж өгөхөд хүрэхгүй гэхийн газаргүй. Литвинов бусад хашгачуур еврей нарынхаа хамт чухам энэ яс нь болно. Хэрэг гарвал шүүх хурал хийлгэнэ. Тэгсэн цагт, эхнэртэйгээ чалчиж байсан юмыг нь баримт болгож тулгана.

Сталин мэдээллийг Берияд өгөхдөө,

– Литвиновыг хэлсэн болгоод дээр нь: “Молотовын дипломат үйл ажиллагаа түүний өөрийнх нь мохоо, богино жолоотойн тусгал юм” гэж нэм, тэгээд мэдээллийг Молотовт үзүүлээрэй гэв.

Ийм мэдээллүүд нөхөр Молотовын мэдрэлийг жаахан маажиг, тэгэхгүй бол дэндүү амгалан, дэндүү гудиггүй байгаа юм.

Берия нөгөө цаасыг Молотовт өгүүлсэн боловч цаадах нь ямар ч хариуц үзүүлсэнгүй. Бахь байдаг амгалан, гудиггүй янзаараа ээлжит ажил явдлаа Сталинд илтгэсээр байж. Тэдгээрийн

дотор Берлинд суугаа Зөвлөлтийн элчин сайдын яамны мэдээ байв. Тельманы эхнэр Роза Тельман элчин сайдын яаман дээр ирж, Германы коммунист намын удирдагч, Зөвлөлт Холбоот Улсын үнэнч анд Эрнст Тельманыг фашистын эрүүгийн хорихоос гаргах гэж оролдохыг Москвагаас гуйсан байна. Үүний хамт амь зуух мөнгө цаас байхгүй, өлөн зэлмэн байгаа, гэхдээ өөртөө бус, германы пролетари нарын жолоодогч Тельманд туслахыг гуйж байна, Зөвлөлт Холбоот Улсын тийм хүсэлтийг Герман татгалзаж чадахгүй гэж итгэж байна гэж хэлжээ.

Тельманы авгай сул байгаа хэрэг үү? Берлинээр зугаалж, элчин сайдын яамдаар орж явдаг байх нь уу?.. Хүн явуулж л дээ. Яах гэж явуулсан нь тодорхой. Нэгдүгээрт, Гитлер түүнээс ялгаатай нь, муусайн авгай хүүхдээс айхааргүй хүчтэй хүн гэх маягтай, дайсныхаа гэр бүлийнхнийг залхаан цээрлүүлдэггүй гэдгээ харуулахыг хүсч байна. Хоёрдугаарт, Гитлер түүний төвч байр суурийг шалгаж байна. тэрээр хэдэн зуун фашизмыг эсэргүүцэгчийг Гитлерт өгч төвч байр сууриа харуулсан. Гэхдээ хариуд нь Тельманыг чөлөөлөхийг гуйх юм бол төвч байр суурь биш, наймаа болно.

– Элчингийнхэн юу гэж хариу өгсөн юм бол?

– “Бид яаж ч туслаж чадахгүй” гэж. Тэгсэн чинь авгай: “Тельманы коммунизмын төлөө хийсэн хамаг ажил талаар боллоо гэж үү? Би Герингэд хандаж болох уу? Надад үгүйдээн энэ тухайд зөвөлгөө өгөөч” гэж уйлсан байна. Тэгэхэд нь: “Энэ бол таны хувийн хэрэг” гэж хариулж.

– За, тийм байж, зөв хариулсан байна гэж Сталин дүгнэв.

тэрээр тийм шалтгаар Гитлертэй хэлэлцээ хийхийг хүсэхгүй. Германд коммунист хөдөлгөөн няц даруулсан, тэгэхээр Тельман цаашид юу болох нь нэгэнт ач холбогдолгүй зүйл. Харин Гитлер дайсныхаа ар гэрийнхнийг залхаан цээрлүүлж байна уу, үгүй юү гэдэг бол түүнд сонин биш. Аль гучин долоон онд тэрээр улс төрийн товчооны шийдвэрийг биечлэн дуудаж бичүүлээд, гарын үсэг зурсан: “Илчлэгдсэн эх орноосоо урвагчид, баруун-троцкистуудын бүх авгай нарыг хорих газар 5-8 жилээс доошгүй хугацаагаар хорьж байх журмыг хойшид тогтоох”. Мөн яг тэр үед өөрийнхөө үзэл бодлыг томъёолж хэлсэн: “Бид дайсан нэг бүрийг, тэр нь ахмад большевик ч байсан хамаагүй устгана, бид түүний бүх үр удам, гэр бүлийг устгана. Өөрийнхөө үйлдлээр, бас санаа бодлоороо, тийм шүү, санаа бодлоороо, социалист төрийн эв нэгдэлд халдаж байгаа хүн болгоныг хайр найргүй устгах болно”.

Харин одоо зуур бол Орост дээр үеийнх нь хилийг эргүүлж авчрах хэрэгтэй. Зөвхөн Финлянд, Бессараби хоёр л үлдээд байна. Финнүүд зөрүүдлээд байна гэж Молотов илтгэв. Финнүүд зөрүүдэлж байна аа?! Балт орчмын улсууд ганц үг ганхийгээгүй, гэтэл эд нар зөрүүдэлж байх юм. Тэд нар чинь, энэ финнүүд чинь хэдүүлээ билээ? Гурав-дөрөвхөн сая... Тийм байж Зөвлөлт Холбоот Улсад буулт хийхийг хүсэхгүй байна уу? Чухамхүү Зөвлөлт засаг тэдэнд тусгаар тогтнол өгснийг мартчихаж. Зөвлөлт засаг өгсөн, зөвлөлт засаг бас өөрөө буцааж авна. Сталин Финляндын засгийн газрын хариуцлагатай төлөөлөгчийг Москвад дуудаж иүүл гэж Молотовт үүрэг өгөв.

Туршлагатай дипломат Паасикиви иржээ. Манай элчин сайдын Хельсинкээс мэдээлснээр

бол, Финлянд бараг тэр чигээрээ цугларч, сүлд дуугаа дуулан түүнийг үдэж өгсөн ажээ. Ямар лут мэдрэмжтэй болж таарч байна аа! Гэтэл мань хүн финнүүдийг номой ард түмэн гэж бодож асан шүү.

Сталинг Молотовын өрөөнд орж ирэхэд Паасикиви босов. Өндөр янхигар финн. Сталин түүнийг дохиж суулгаад, юун дээр бэрхшээл байгааг тайлбарлаж өгөхийг хэлмэрчээр дамжуулан хүсэв. Уг нь ЗСБНХУ тун сайхан болзол санал болгож байгаа шүү дээ: финнүүд хилээ Ленинградаас холдуулна, оронд нь тэд хавьгүй их газар нутаг Карелиас авна. Юу нь муу байна?

Хэлмэрч Паасикивийн хариултыг орчуулав.

– Ноён Сталин, ийм юм л даа, манай үндсэн хуулийн дагуу нутаг дэвсгэрийн асуудлыг гагцхүү сейм шийднэ. Асуудлыг эерэгээр шийдэхийн тулд гуравны хоёроос доошгүйн санал хэрэгтэй. Миний болгоомжилж байгаа юм бол...

– Та юунаас ч болгоомжлохгүй байж болно хэмээн Сталин үгийг нь бүдүүлгээр тасдав. – Та нар гуравны хоёроос илүү санал авна, тэгээд дээр нь бас манай саналыг бодолцоорой.

Энэ бол ацан санаагүй заналхийлт. Гэвч финнүүдэд нөлөөлсөнгүй.

Сталин цэргийн зөвлөл дээр,

– Одоо яая гэхэв, тэгвэл их буу ажиллаж эхэлнэ. Анхны буун дуунаар финнүүд хоёр гараа өргөх болно гэж мэдэгдэв.

Ворошилов, Тимошенко хоёр аль аль нь түүнтэй санал бүрэн нийлэв.

Арван нэгдүгээр сарын 30-нд Зөвлөлт Холбоот Улс Финляндтай дайн хийж эхлэв.

Гэтэл финнүүд гараа өргөж бууж өгсөнгүй. Паасикивийг явах өдөр сүлд дуугаа дэмий дуулсан хэрэг биш бололтой. Финляндын жижигхэн ард түмэнтэй хийсэн дайн төлөвлөж байсан шиг ес хоног биш, зуун дөрөв хоног үргэлжлэв. ЗСБНХУ энэ дайнд 76 мянган хүнээ алуулж, 176 мянган хүн нь шархадсан, остосон байна. Тэгэвч бүрэн ялалт байгуулж чадалгүй, гуравдугаар сарын 13-нд дайныг дуусгажээ. Зөвлөлт Холбоот Улс цэргийн сулхан байдлаа бүх дэлхийд илчиллээ.

Варя Эрхүүгийн буудал дээрээс Уфа руу, Ленад, өөрөө авагч гэсэн хаягаар цахилгаан явуулав: “Амралт дууссан гэртээ харьж явна”. Ойлгоно гээд цахилгаан дээрээ нэрээ тавьсангүй. Москвад ирэхэд нь Ленагийн хэдэн захиа шуудан дээр байж байв. Ажил олсон, нийтийн байранд орсон, чиний ажил төрөл ямар байна? гэхчилэнгийн ажил хэрэгч товчхон захидлууд. Тэр хоёрын тохирсон ёсоор Ванягийн тухай нэг ч үг алга. Варя тэр даруй цахилгаан явуулав: “Захидлуудыг авсан, бүгд бие сайн, сэтгэл урамтай байна, дэлгэрэнгүйг захиагаар”. Захиандаа амралтаа сайхан өнгөрүүлсэн, амсхийсэн, тэвээрсэн, наранд шарсан, хамаатнууд нь сайн хүлээж авсан гэж бичжээ. Энэ бүхэн Ваняд хамаатайг Лена ойлгоно.

Игорь Владимирович түүний Алс Дорнод руу явж ирснийг мэднэ, тухайн үед тасалгаатай вагоны тасалбар олж өгсөн, Варя задгай вагоноор ч хүрчихэлгүй яахав хэмээн жаахан харууссан.

– Нэг жижигхэн бэлэг барья, битгий дургүйцээрэй гэж Игорь Владимирович хэлээд, – Үгүйдээн жаахан ч болохноо тухтай яваасай гэсэндээ энэ шүү гэжээ.

– Одоо хүүхнүүдэд төмөр замын тасалбараар бэлэг барьдаг болсон юм уу?

Цаадах нь инээж,

– Цэцгээр барих ёстой. Гэтэл та цэцгийг буцаасан гэв.

Ийнхүү тоглоом наргианы байдалтай тэд тэгэхэд салцгаасан билээ. Буцаж ирэхэд нь тэрээр баяртай угтсан, элдвийн юм асуугаагүй, зөвхөн,

– Таны танилын ажлын талаар би тохирсон. Гэхдээ тийм шаардлага нэгэнт алга болсон гэж ойлгосон гэж хэлжээ.

– Яагаад та тэгж ойлгоов?

– Утасдаагүй.

– түүнийг Москвагаас цөлсөн хэмээн Варя энэ яриаг дуусгахын тулд товчхон өчив.

Гэвч яриаг дуусгавар болгож чадсангүй. Игорь Владимирович үгээ цэнэн сонгож байгаад нухацтай гэгч нь,

– Варя, би зүгээр л нөхөр ёсоор таныг болгоомжтой байгаарай гэж хэлэх гэсэн юм гэв.

– Би юу хийчихсэн болж байна?

– Та заримдаа өөрийнхөө санааг дэндүү илэн далангүй хэлчих юм. Нэг их цаг үеэ олсон гэмээргүй санааг гэх үү дээ. Үүнийг чинь танд ашиггүйгээр мушгин тайлбарлаж болох талтай.

– Таны юун тухай ярьж байгааг би ойлгохгүй байна.

Цаадах нь үгээ бас л сүрхий цэгнэн байж ийн өгүүлэв:

– Таны нэр нэг л эрүүл бус сонирхол татаад байх болсон шиг, зарим нэг хүн таны зан аягийг ажиглаад байх шиг надад санагдах боллоо. Техникийн хэлээр хэлэх юм бол осолтой байдлын түвшин нэмэгдлээ, тэгвэл, болгоомжийн түвшинг нэмэгдүүлэх хэрэгтэй гэсэн үг.

– Тэглээ ч гэсэн, хов хоосон юмнаас болж гэнэт намайг сонирхоод эхлээгүй байлгүй? Таны ингэж болгоомжлоод байгаа чинь Лена Будягинатай холбоотой юу?

– Мэдэхгүй. Нэгэн үеэс эхлээд намын хороо таны тухайд, юу гэж хэлмээр юм бэ дээ, хүйтэвтэр ч гэх үү хандах болсныг би мэдэрсэн. Би энэ тухайд андуураагүй л болов уу.

– Би өөр газар шилжих хэрэгтэй юм болов уу?

– Хэрхэвч болохгүй. Өөр газар та бүр өмгөөл хамгаалгүй болно. Танд миний энд арай тайван, арай осол багатай байх болно, Варя. Бас миний дэргэд гэж хэлээд хоолой нь чичрэх аядав. – Гэхдээ би таныг болгоомжтой байхыг уриалж байна, Варенька, би танаас гуйж байна.

түүний энэ сэрэмжлүүлгийн цаана юу байна вэ? Лав л санаандгүй биш. Өөртөө татах гэсэн арга биш. Игорь Владимирович өөрт нь сэтгэл алдсанаа нуудаггүй, гэхдээ хуурамч аюулаар айлгахгүй. Нэг л юм байна даа. Ажлын газрынх нь эмсийн хов жив юм уу? Эмсийн хов жив биш болж таарлаа.

“БХК(б)Н-ын товч түүх” хэвлэгдэж, бүх байгууллага, үйлдвэр, сургууль дээр түүнийг нийтээрээ заавал судлах ажил эхлэв. Долоо хоногт ажлын дараа хоёр цаг. Хүн болгон тэр сурах бичгийг худалдаж авав.

Варя ажил дээр нь авчирч рубль хэдээр зарсан тэр номыг бусдын адил худалдаж авав. Метрогоор харьж явахдаа баахан эргүүлж үзвэл, эхлээд мөр алгасаад Ленин гэсэн, дараа нь мөр болгондоо Сталин гэсэн тэр балай юмнаас дотор нь муухайрчээ. тэрээр “Товч түүх”-ийг сургууль дээрээ үзэж байгаа гэж ердийнхөө аргыг хэрэглээд эхний хичээлд ирсэнгүй.

Гэвч энэ удаа тэр арга нь баарчээ. “Товч түүх”-ийг сургууль дээрээ үзэж байгаа гэсэн албан ёсны магадлагаа авчирч өгөхийг шаардаж. Сургууль нь тэр хичээлийг ажлын газар дээрээ үзэх ёстой, тэр орой нь оюутныг хичээлээс нь чөлөөлдөг гэжээ. “Товч түүх”-ийг иргэдээр судлуулахыг төрийн ийм онцгой ач холбогдолтой ажил болгосон аж.

Левочкагийн хэлснээр: “Варя хавханд оржээ”. Рина юм хэлсэнгүй.

Яг тэр өдрөө Варяг үйлдвэрчний хорооны дарга Ириада Тихоновна хэмээх ус сувгийн хэлтсийн инженерийн албатай, ам хэлтэй, ажлын хөөцөлдлөгтэй, бүдүүн авгай руу дуудав. Инженерийн хувьд авьяас билэг гэхээр юмгүй, тиймийн учир үйлдвэрчний ажлыг идэвхитэй, хичээнгүйлэн хөөцөлдөнө. Гэхдээ хорлонтой биш, боломж гарвал тус болох гэнэ. Чухамхүү тэр л тухайн үедээ Варяг: “Хүн суралцаж байна, залуу нөхөр мэрэгшлээ дээшлүүлж байна”

гэж өмгөөлж байжээ.

– Варя, миний чамд яаж ханддагийг чи мэднэ. Чамайг өсч яваа залуу мэргэжилтэн гэж бид цөмөөрөө үнэлдэг. Чи “Товч түүх”-ийг сургууль дээрээ үзэж байгаа гэж биднийг хуурсан байна. Тэр чинь худлаа болж таарсан. Варя, чи биднийг айхтар хөөдлөө гэж Ириада Тихоновна мэдэгдэв.

– Хэнийг хөөдсөн гэж?

– Бүх байгууллага зуун хувийн ирц, оролцоотой байгаа. Манай хамт олон ердөө дөчхөн хүнтэй болохоор тасалсан хүн болгон манай үзүүлэлтийг эрс бууруулж байна.

– Тэр үзүүлэлтээс болж би хичээлээ таслах хэрэг үү?

– Оройн ангийнхныг тэр өдөр хичээлд очихгүй байхыг зөвшөөрсөн.

– Би намын гишүүн биш, намын түүх судалж байх албагүй.

Ириада Тихоновна мэл гайхчихав: ямар муухай шазруун зан бэ! Намын түүхийг судлах албагүй гэнэ!

– Нөхөр Иванова! хэмээн Ириада авгайн дуу албархаад явчихав. – Та захиргааны тушаалыг уншсан уу, бүх ажилтанд зарласан, тэр тушаал самбар дээр өлгөөтэй байгаа.

– Санахгүй байна, самбар дээр өлгөөтэй юм алийг тэр гэхэв.

– Би танд сануулья: “Бүх ажилтан БХК(б)Н-ын товч түүх”-ийг судлах хичээлд суух үүрэгтэй” гэж байгаа. Та тушаал зөрчсөн байна.

– Магадгүй. Тэгвэл донгодуулах нь.

– Намын гишүүн биш хүн манай намын түүхийг судлах ёсгүй гэсэн таны мэдэгдэл бол коммунистууд, нам бусчуудыг эсрэгцүүлэн тавьж байгаа хэрэг.

– Тийм үү? хэмээн Варя гайхав.

– Тэгэхгүй яахийм! Манай оронд коммунистууд болон нам бусчуудын эвсэл байгаа, та тэр эвслийг хагалан бутлахыг хичээж байна.

– Тийм хүчирхэг эвслийг би хагалан буталж чадах уу?!

– Иванова! Намайг тэнэг юм гэж бүү бод! Би таныг өмөөрдөг байсан, одоо харамсаж байна. Чамд олон юм бий шүү, Иванова, маш олон юм. Та сургуулиараа халхавч хийж, биднийг аль хэзээнээс мэхэлж байгаа. Та нэг ч жагсаалд оролцож байгаагүй, бүх хурал цуглаанаас дайжиж байсан. Бүх ажилтан нар сарынхаа цалингаар, би бол, жишээ нь хоёр сарынхаараа зээллэгийн сугалаа захиалж байхад та гуравхан долоо хоногийнхоор захиалсан.

– Та бол надаас баян гэж Варя зөрөв. – Би бол жирийн техникч, та бол ахлах инженер, бас нөхөр чинь тань шиг, нэг газар ахлах инженер.

Ириада Тихоновнагийн хацар мэнчийгээд, нүд нь онийгоод ирлээ. Тэгээд шазуур зуун,

– Тийм, миний нөхөр инженер, харин таных бол луйвар хийсэн, социалист өмч шамшигдуулсан хэргээр ял авсан гэв.

– Наадах чинь худлаа. Надад нөхөр байхгүй, байгаа ч үгүй. Харин миний хэнтэй унтах нь хэнд ч падгүй явдал. Би таны хэнтэй унтдаг, хэн нэгэн тантай унтдаг эсэхийг би сонирхохгүй.

Ириада Тихонвона Варягийн өөдөөс дуугүй харснаа, амьсгаадан ярьж алдав:

– Өнөөдрийн энэ яриа танд хатуухан эргэж бууна даа, Иванова, яллагдсан нөхөр, намаас хөөгдсөн эгч, таны захидлаар харилцдаг цөлөгдсөн троцкист энэ тэр гээд олон юмыг чинь эргэн санацгаах болно. Бид таны бүх юмыг мэднэ. Хуу илчлэнэ дээ. Бид танаас хүчтэй, энийг мэдэж ав.

– Би таны занасныг тогтоож авна, та ингэснийхээ төлөө хариуцлага гарцаагүй хүлээнэ.

Варя босч, тэдний өрөөнөөс гарав. Ириадын занасныг тогтоож авна гэж яагаад амласан, яагаад тэгсний төлөө хариуцлага хүлээнэ гэж сүрдүүлснээ Варя өөрөө мэдэхгүй байж. Энэ муухай өрөөнөөс доромжлуулж гарахгүй, сүүлчийн үгийг өөрөө хэлэх ёстой гэж бодсоных юм болов уу.

Гэхдээ эд нар хаанаас энэ бүхнийг цуглуулдаг байна аа? Удаан цуглуулсан бололтой, Игорь Владимировичийн битүү дохио санаандгүй зүйл биш юм байна. Ашгүй Ленагийн тухай юу ч мэдэхгүй юм шиг байна, яамай даа, ээ Бурхан минь.

Улс төрийн хэрэг наачихаагүй дээр нь эндээс гарах хэрэгтэй, гарна чиг, тэгээд өөрийг нь мартана. Харин зохион бүтээгч-техникчид хаа сайгүй хэрэгтэй. Игорь Владимирович өөрт нь сайн тодорхойлолт хийгээд өгнө.

Игорь Владимирович түүний өрөгдлийг уншлаа. Товчхон өрөгдөл: “Өөрийн хүсэлтээр чөлөөлөхийг хүсье”. Уншчихаад ширээн тавьж,

– Энэ чинь маргааш болтол тэсч болох сауудал уу? гэж асуув.

– Маргааш юу өөрчлөгдөх билээ?

– Та өнөө орой завтай юу?

– Сургууль руугаа очно.

– Сургууль руу явахаа больчих. Би тантай ярилцмаар байна. Энэ бол маш чухал. “Националь” кафед жаахан сууцгаая. Тэгэхэд бидний танилцсан газрыг санаж байна уу?

Тэр хоёр “Националь” кафед цонхны дэргэдэх жижгэвтэр ширээний ард суулаа. Дөрвөн жилийн өмнө тэд энд, гэхдээ хоёрдугаар давхарт, ресторанд сууж байсан билээ. Вика швед Эриктэй, хөөрхөн Ноэми японтой, Нина Шереметева италитай байцгаасан. Вика Парист байгаа, Ноэми нэрт зохиолчтой суусан, Нина Шереметева бараг л хаан ч бил үү, хунтайж ч бил үү, нэг эрхэмтэй суусан, Варя энэ бүхнийг Левочка, Рина хоёрын ярьснаас мэднэ. Энэ бүхэн аль хэзээ болсон, зуун жил өнгөрсөн юм шиг, Варя тэр амьдралыг ерөөсөө санагалздаггүй, харин ч дургүй нь хүрдэг. Ганц аятайхан дурсамж нь Игорь Владимировичтой уулзсан явдал, тэр өөрт нь таалагдсан, дараа нь энэ нь мань эрийн хувьд хайр дурлал болж хувирсан, хэдийгээр өрөөсгөл ч гэсэн тэвчээртэй, мятрашгүй хайр. Хэрэв тэр үед Варя түүний хайрыг хайраар хариулсан бол амьдрал нь өөр гольдролоор явж, Костятой заваарсан нөгөө булай явдал болохгүй байсан. Нээрэн, бас Саша ч байхгүй байх байсан, гэхдээ Саша тэртэй тэргүй алга, бий болох ч үгүй... Амьдралаар баярлан гайхах сэтгэл, цэнгэж өгмөөр, гоё сайхан ертөнцөд жаргах горьдлого энэ тэр үгүйрэн арилжээ. тэрээр энэ ертөнц нь шудрага бус, хатуу ширүүн, хайр найргүй гэдгийг одоо мэднэ.

Игорь Владимирович өөртөө дарс, Варяд чөмөгт боовтой кофе захив. Варя ажил дээрээ юм идчихсэн гээд хоолноос татгалзсан аж. Игорь Владимирович “Товч түүх”-тэй холбоотой явдалд санаа нь зовж, сэтгэл зовнингүй буйг Варяд мэдрээд байв. Дайчин эр биш юм. Гэхдээ одоо дайчин эр хэн байна? Энэ бол журамтай хүн, манай нөхцөлд их юм, одоо маш ховордсон чанар.

Зөөгч захиалгыг нь авчирч өгөөд холдоход, Игорь Владимирович хажуугийн ширээнийхэнд дуулгахгүй санаатай, Варя руу хазайсхийгээд,

– Варенька, бид чухал юм ярих ёстой, миний амьдралын хамгийн чухал яриа гэж өгүүлэв.

тэрээр хундагатай дарснаасаа балгаснаа, тамхиа асааж, үнсний сав руу удаан харж байгаад шүдэнзээ унтраав.

– Тийм учраас Варя, миний хэлэх юманд буурьтай хандахыг хүсье. Бас бүрэн итгэхийг хүсье. Намайг найдвартай андаа гэж үзэхийг би хүсч байна.

– Таныг би хэзээ ч найдвартай андаа гэж үзэж ирсэн. Би ч бас таны үнэнч найз гэж Варя түүний догдлон бүхийд сэтгэл хөдлөн хариулав.

– Маш сайн байна. За тэгэхээр, та ажлаас гарах тухай өрөгдөл өгсөн, таныг тойрсон булай явдлыг тийм байдлаар зогсооно гэж найдаж байна. Та ингэснээр ямар ч үр дүнд хүрэхгүй гэдгээ маш сайн ухаарах ёстой, Варя. Тэд нар таныг хаа л бол хаанаас олно, тэд аль хэзээнээс нааш таныг ажиглаж байгаа. Бид бүгдээрээ данстай. Ажилтан болгонд хувийн хэрэг байгаа, түүн дотор нь төрөл төрөгсөд, танил тал хүмүүс, алба ажил, тодорхойлолт, бүх “матаас” гээд бүгд бий. “Товч түүх”-ээр та тэдэнд цогоо үлээж эхлэх шалтаг өгсөн. Ириада Тихоновна улаан галзуу байна лээ, би түүнтэй ярьсан, та түүнийг хувь хүнийх нь хувьд дайрсан бололтой юм.

Варя дал мөрөө хавчив.

– Эмсийн л яриа болсон, тэр намайг доромжилсон, би хариуг нь өгсөн. Гойд юм юу байна?

– Ойлгомжтой. Гэхдээ тэр чинь бүх юманд улс төрийн аяс оруулаад байна: “Нам бусчууд намын түүхийг судлах албагүй, коммунистууд л үздэг юм байгаа биз” (та түүнд тэгж хэлсэн мэт), эгч чинь намаас хөөгдсөнийг та нуусан, та цөлөгдсөн троцкисттой захидлаар харилцдаг, цаашид ч харилцана гэнэ.

– Би тэгж хэлээгүй.

– Тэр чинь юу ч хамаагүй зохиож чадна. түүний зөөлөн сэтгэл чинь зөвхөн өнгөнийх: тийм байвал үйлдвэрчний хороонд тэсээд байх боломж илүү, тэгж байж “хамт олны дотор нэр хүндтэй байгаа”, уг чанартаа бол яг өөр шигээ амьтдын нэгэн адил хорон санаатан. Манай нийгэмд хэнд ч болдоггүй зүйлийг та болгож байснаа өөрөө хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тэр Ириада Тихоновна чинь гэхэд л таны эсрэг хэргийг маш амархан зохиочихно. Та тэдний өмнө хүч мөхөсдөнө. Та хамаг юмаа хаяад эгч рүүгээ яваад өгч болно, гэхдээ дуудлага ирүүлэх, үнэмлэх авах энэ тэрд бишгүй цаг зарна, таныг амжина гэдэгт би итгэхгүй байна. Гэтэл амжлаа гэхэд тэнд таныг юу хүлээж байх вэ? Ажил уу? Биеийн байцаал бөглөх ёстой болно, тэд нар сүүлчийн ажиллаж байсан газраас чинь, өөрөөр хэлбэл, манай Моспроектоос асууна, бүгд илрэнэ, тодорхой болно, тэгээд тэд нарын гар танд хүрнэ. Өөр юу үлдэж байна? Ямар нэг дэслэгчтэй суугаад, овгоо өөрчилж, биеийн байцаал бөглөхгүйн тулд гэрийн эзэгтэй болж болох.

Варя толгой сэгсрэв. Нинка Москвагаас ямар ч асуулгагүйгээр сургуулийн ажилд орсон. Алс Дорнод өөр шалтгаанаар болохгүй: тэнд бяцхан Ваня байгаа, өөрийг нь умард руу дайчлагдсан гэдэг тайлбар бодож олсон, тийм учраас өөрөө тэнд харагдах ёсгүй.

Игорь Владимирович толгой сэгсэрснийг өөрийнхөөрөө тайлбарлав.

– Тийм л дээ. Би ингэж бодож байна: тийм амьдрал таных гэж үү? Үл мэдэгдэх ирээдүйн нөхөр чинь хэн болж таарах бол?

тэрээр дуугай болж, хундаганыхаа шилбийг нарийнхан хуруугаараа илэх зуур бодолхийлэв.

– Та өөр хүнд хайртай, түүнийгээ хүлээж байгаа гэж хэзээ нэгтээ хэлж байсан. Танд итгэхгүй байх үндэс надад байхгүй. Гэхдээ тэр хүн чинь хаана байна?! Та тэгэхэд: “Тэр хүн нэг жилийн дараа буцаж ирнэ” гэж хэлсэн. Одоо гурван жил өнгөрчихөөд байна. Хэрэв тэр чинь байгаа бол, таны аминд орж, өөр рүүгээ аваачиж, аюулгүй болгох чадвартай юу? Хэрэв чадах бол таны баримт бичгийг бүрдүүлж өг гэж би тушаая, тэгээд тэр хүн рүүгээ нэн даруй яв. Гэтэл, Варя, хэрэв ийм юм ерөөсөө байхгүй бол, хэрэв та энэ бүхнийг надад эелдгээр татгалзахын тулд хэлсэн бол танд ердөө ганцхан гарц байна гээд түр азнаснаа, Варягийн нүд рүү харж байгаад, – Надтай суух гарц гэж эрсхэн хэлэв.

Варя дуугарсангүй. Игорь Владимировичийг: “...бид чухал юм ярих ёстой, миний амьдралын хамгийн чухал яриа” гэж хэлэхэд л өөрт нь суух санал тавих нь гэдгийг Варя ойлгосон ажээ.

Энэ яагаад “тийм” гэж хэлж чадахгүй байна? Уг нь Игорь Владимировичид их сайн, түүнд

итгэдэг, түүнийг үнэлдэг, гэтэл нэг юм саад болоод, тээглээд байна. Саша юу? Биш, Сашаг горьдох юмгүй болсон, энэ бол тодорхой. Тэглээ ч гэсэн Саша, хувь заяанд нь орж ирж чадаагүй Саша бол өдий хүртэл амьдралынх нь нэг хэсэг болж яваа, харин энэ ялдамхан Игорь Владимирович, энэ сайн хүн бол тэр амьдралынх нь гадна мэт байгаа. Өөрөө түүнд сэтгэлгүй. Тийм учраас “тийм” гэж хэлэх эрхгүй.

Игорь Владимировичийн дуу түүнийг бодлоос нь салгав.

– Шууд шийдэхэд хэцүү байгааг би ойлгож байна. Гэхдээ танд эрэгцүүлэх зүйл нэммээр байна. Юуны өмнө практик тал нь. Хэрэв та миний саналыг хүлээн авч байгаа бол хоёулаа яг маргааш бүртгүүлэе.

– Шууд бүртгүүлж болдог юм уу?

– Биднийг бол бүртгэнэ. Тэгээд та бас маргаашдаа ажлаасаа гарна. Нэг, хоёр сарын дараа, манай бүх юм намжисхийхээр, би таныг өөр газар ажилд оруулъя, мэдээж, таныг хүсвэл шүү дээ, би шинэ жилийн дараа тийшээ шилжих юм. Би шинэ том төсөл эхэлж байгаа. Эсвэл, та өдрийн ангид шилж, энэ бол арай дээр гэхээр хувилбар, тэгвэл оройн цагаар завгай байх болно, ажил гэдгээс чинь гадна театр, концерт, үзэсгэлэн энэ тэр гээд таны одоо хэрэг дээрээ үзэж чадахгүй байгаа юмнууд бий шүү дээ. Гэхдээ энийг бол та өөрөө л шийднэ. Манай ажил дээр болох явдлыг би ингэж төсөөлж байна. Та миний авгай, манайд ажиллахаа больсон. Таны эсрэг элдэв яриа дэгдээх үү? Тэгвэл тэр нь миний эсрэг дэгдээж байгаа хэрэг болно.

– Гэхдээ таны эгч биш, минийх намаас хөөгдсөн шүү дээ.

– Энэ чинь тодорхой утгаар миний ч намтрын нэг баримт болно. Гэхдээ тэд миний эсрэг юм хийхгүй, тэд бол миний ямар түвшинд заргалдаж чадахыг мэдэх хэмжээний ухаантай. Тийм учраас энэ талаасаа бол юмны учир олдоно. Гэхдээ, Варя, бас өөр нэг тал байна.

тэрээр дарсаа дуустал ууж, дахин тамхиа нэрээд, шүдэнзээ дуустал шатааж үнсний сав руу хаяв.

– Аргагүй байдлыг чинь далимдуулж байна гэж бодох вий л гэж би хамгаас илүү айж байлаа, Варя минь. Тиймгүй шүү. Та надаас дандаа зай барьдаг, би энүүнд чинь дасчихсан, цаашид ч тэвчээд л байх байсан байх. Гэхдээ би таныг баллахыг хэрхэвч зөвшөөрч чадахгүй. Таныг хувь хүний чинь хувьд зөвхөн өндөр үнэлдэгтээ тэгж байгаа юм биш, танд хайртайдаа тэгж байгаа юм. Та эрэлхэг зоригтой хүн учраас бусдын төлөө гэхээрээ аюулыг тоомсорлохгүй юм. Гэхдээ бүх юм таны бодож байгаагаас хавьгүй ноцтой, үүнд үнэмшиж мэдэж авах хэрэгтэй. Миний санал бүх асуудлыг шийдэж байгаа юм, та надтай байхад аюул осолгүй болно. За одоо хэлэх гэсэн гол юмаа хэлье. Би танд хуурамч гэрлэлт санал болгож байгаа юм биш, тэгэх юм бол надад ч, танд ч өөрсдийгөө доромжилсон явдал болно. Би таныг надад хайр сэтгэлтэй болох болов уу гэж найдсандаа танд хайр сэтгэлээ, үнэнч явах сэтгэлээ санал болгож байна. Тэгэхээр та хайранд хайраар хариу өгөх хүсэл байж гэмээнэ л миний саналыг хүлээн авч болох юм. Та өөрөө хэзээ ч наймаалцахгүй, тэгнэ гэхэд та дэндүү журамтай хүн, харин энэ асуудал бол тов тодорхой байх ёстой. Та миний саналыг хүлээн авах юм бол та миний авгай, би таны нөхөр болно, Бурханы авралаар, та бид хоёр хайрлаж явах үр хүүхэдтэй болно, за

тэгээд бид бас дундын ажил үйлстэй болно. Цагийг эзэгнэдэг юм гэж байна, Варя, тэр бол та бидний бүтээж байгаа зүйл. Энэ маань биднийг хүний зовлон, гунигаас ангижруулахгүй, гэхдээ энэ нь өөрсдийнхөө ажлаар, өөрсдийнхөө урлагаар хүн ардад жаахан ч гэсэн баяр, тайтгарал өгөх боломжийг бидэнд олгож байгаа. Та их авьяастай, энэ замд чинь таныг сайхан ирээдүй хүлээж байгаа. Адлуулсан, шоовдор хүмүүст таны үзүүлж байгаа тусламж урлагийн бүх бүтээлээс дээгүүр гэж та одоо бодож байгааг би мэдэж байна. Тэр тухайд тантай санал нэг байна. Гэтэл таны хүрч чадах тэр өндөрлөгөөс бол та энэ тусламж, энэ өрөвч сэтгэлийн өгөөжөө хавьгүй өргөн цар далайцтай үзүүлж чадна.

мань хүн гэдийн сандлын түшлэг налж, гунигтай инээмсэглэн түүн рүү харав.

– Пфү... Ийм урт үг хэзээ ч хэлж явсангүй, таныг зүдрээчихлээ. Одоо, Варя, таны ээлж.

Варя хариуд нь бас инээмсэглэн,

– Та өнөөдөр ажил дээр байхад надаас: “Энэ чинь маргааш болтол тэсч болох асуудал уу?” гэж асуусан. Одоо би энэ асуултыг танд шилжүүлж байна.

– За яахав, маргааш гэж байгаа бол маргааш л болог.

Тэр хоёр Горькийн гудамж руу гарцгаав. Варя,

– Намайг үдэх хэрэггүй, би метрогоор гурван буудал яваад л харьчихна гэв.

– За тийм байж хэмээн Игорь Владимрович санал нийлэв. – Тэгвэл маргааш хүртэл баяртай. Бодож үз. Гэхдээ, Варя, та юу гэж ч шийдлээ гэсэн, таны хувь заяа яаж ч эргэлээ гэсэн, би таны хойноос хаашаа ч хамаагүй явахад бэлэн гэдгийг мэдэж байгаарай.

Варя гэр рүүгээ явган явав. Метронд чихэлдэх дур байсангүй.

түүний байдал ноцтой буй. Цуглаан зохион байгуулаад л, “дайсны элементийг” хамт олноос цэвэрлэхийг шаардана, дараа нь хамгаалахынхан залгаад ирнэ. Зохиомж тодорхой.

Игорь Владимировичтой сууна гэдэг бол аврагдах цорын ганц боломж. Энэ боломжийг ашиглах эрх түүнд бий юү? Хэргийн учир Сашад байгаа юм биш, Сашагийн хувьд мань хүн байхгүйтэй адил, ийм байдалтай эвлэрэх цаг аль хэдийн болсон. Гэтэл Игорь Владимировичид хайргүй гэж өөртөө олон удаа итгүүлж ирсэн. түүнд дургүй нь хүрдэггүй, харин ч аятайхан байдаг, тэгсэн хэрнээ танилцсан анхныхаа өдрөөс л түүнийг нөхрөө гэж төсөөлж нэг л чадахгүй яваа. Тэгэхэд жаахан охин байсан болохоор түүнд хөгшин юм шиг санагдсан байж магадгүй. Гэтэл мань хүн Костягаас ахгүй шүү дээ. Костя тэгэхэд хараат бус байдлын гэгээнд тодорч байсан бол Игорь Владимирович хараат байдалд байсан. Костя оршин бүхий дэг журмыг, өөрийнх нь тэр үеийн ойлголтоор, хүлээн авахгүй байсан бол Игорь Владимирович хүлээн авч байсан. Энэ бол тэнэг харьцуулалт. Костя бол бильярдчин, панзчин, мөрийчин, эрүүгийн ертөнцийн хуулиас хамаарна, тэрэнд нь төрийн хууль бус ёсноос дээр юм юу ч байхгүй. Тэр хоёр хамт амьдарч чадах эсэхийг өөрөө маш сайн төсөөлөх ёстой. Түүгээр бахархаж явах уу, эсвэл ичиж явах уу? Авьяастайнх нь хувьд, гарамгай хүнийх нь хувьд бахархах болно. Гэтэл өнөөгийн авьяастнууд хэнд, юунд үйлчилж байна вэ? Нөгөө л сахалтай хоншоорын төлөө. Тэр чинь нэмэрт нь Игорь Владимировичийг ивээж байгаа. Тэгэхээр юугаар бахархах болж байна? Үзэсгэлэнгээр нь, шагналаар нь, магтаалын өгүүллүүдээр нь, элдэв баяр хүргэлт энэ тэрээр нь үү? Хичнээн хүний адаг, өчүүхэн амьтдыг тэгж хөхиүлж байгаа билээ дээ!

түүний төлөөнөөс өөрт нь ичгүүртэй байх уу? Өнгөрсөн бүхий л хугацаанд, үйлдвэрчний хурал дээр өөрийнх нь тодорхойлолтыг хачин албаны хэлээр ярихад л ганц удаа гонсойсон. Бас нэг удаа Костягийн янхан хүүхнийг ресторанаас өөрөө шууд хөөж явуулахын оронд цагдаад өгнө гэж дүрэмдэхэд нь хулчгар амьтан гэж бодсон тал бий.

Дэмий тэгж бодож, шудрага бус юм болж. түүний төлөөнөөс ичих явдал гарахгүй нь. Тэр алба хашиж байгаа нь үнэн, гэтэл өөрөө ч бас хашиж байгаа. Москваг шинэчлэн байгуулах төсөл бол агуу их сталинч эринийг олон зуунд илтгэн харуулж байх ёстой, мань хүн уг төслийн зохиогч. Өөрөө бол жирийн техникч, гэхдээ бүхний адил бас л алба хашиж байгаа. Амьдрах хэрэгтэй, идэж уух хэрэгтэй, бас, юу гэж ч ярьдаг байлаа гэсэн, хот суурин босгож байгуулах ёстой. Тэгвэл Игорь Владимирович долигонох буюу бузар аргаар энэ байр сууриндаа хүрээгүй. Адлуулсан, шоовдор хүмүүсийг дотроо өрөвдөнө, Лена Будягинад ажил олж өгөх гэж хөөцөлдсөн, Ваняг авч явахад тусалсан.

Тэр хоёр нэг удаа Волхонкоор, Зөвлөлүүдийн ордон барьж байсан талбайн хажуугаар явж байсныг Варя санав. Тэгэхэд Варя, түүнээс яагаад ордны төслийн уралдаанд оролцоогүйг нь асуусан, түүний оролцоогүйг тэгэхэд хэн хүнгүй гайхаж байсан юм.

мань хүн инээд алдаад,

– Зөвлөлүүдийн ордон босно гэхээс хэн хамгийн их айж байсныг мэдэх үү? Хэзээ ч таахгүй гэж толгойгоороо дэнчин тавья гэсэн.

Варя хэдэн нэр хэлсэн боловч таагаагүй. Тэгсэн чинь Гитлер юм байж! Москва энэ аврага ордонг сүндэрлүүлчих юм бол Берлинг тоосгүй хаяна, ингэхийг фюрер хүсэхгүй буй.

– Та Гитлерийн сэтгэлд юм хийхийг хүсээгүй болж таарч байна уу?

– Тэгж таарч байна.

– Үнэнхээсээ бол?

– Үнэнхээсээн үү?.. Нураасан Авралын эзэн Христийн сүмийн байран дээр Ордныг барьж байгаа. Шашин, сүм дуганд ер нь, тухайлаад энэ сүмд янз янзаар хандаж болно. Тэр сүмийг Наполеоныг бут цохисон ялалтад зориулж, Орос даяараас зоос зоосоор нь мөнгө цуглуулж байж, ард түмний хөрөнгөөр барьсан юм. түүнийг нураах ажилд би яаж оролцох сон билээ.

Игорь Владимировичтой амьдарвал, энэ оронд амьдрал ямар дайтай нэр төртэй байж болох вэ, тэр дайны нэр төртэй амьдрал болно, тэр бол тийм.

Хэдий тийм чиг... түүнийг дахиад, хоёр дахь удаагаа гэрлэснийг мэдээд Саша юу гэж бодох вэ? Эхний удаа — азтай мөрийчинтэй, хоёр дахь удаагаа — өөдлөн дэвшиж яваа уран барилгачинтай гэж бодох уу? Муу л юм бодно. мань хүнийг улс орноор хөөгдөн, орох оронгүй, байх суух газаргүй тэнүүчилж явахад, өөрөө сайхан байранд сууж, гоё концерт энэ тэр үзэж явах нь. Сашаг горьдсоны гарз, гэхдээ тэрээр түүний нүдэнд баян харчуул хайж явдаг, хямдхан амьтан болж үлдэхийг хүсэхгүй байна.

Саша яагаад түүнтэй уулзахыг хүсээгүй юм бол?! Калининд очоод, галт тэрэгний буудал дээр хамт суузанад, ярьцгааж болох л байсан, тэгсэн бол мань хүн бүх юмны учрыг ойлгох байсан, тэгсэн бол хамаг юм өөрөөр эргэх байсан. Харин одоо бол Саша дахин сэтгэл гонсойсноо, бас нэг урвалтыг түүний нэртэй холбох болно. Бас юуг ч өөрчлөхийн аргагүй.

Сашатай юу ч бүтсэнгүй, бүтэх ч үгүй, хий мөрөөдөж одоо бол оо. Нөхцөл байдал хүнтэй суухаас өөр аргагүй болгож байна. Игорь Владимировичоос сайн хань олно гэж байхгүй, өөр тийм ухаантай, журамтай, хайртай, санаа тавьдаг хүн таарахгүй. Тэгэхээр хойш тавихын хэрэггүй, тэр ч яаруулж байна, мань хүн маргааш юм уу, нөгөөдөр тэднийд, Горькийн гудамж руу нүүж очно. Тэгээд цаашаа... Цааш нь олон юм санаа зовоож байна. түүнийг яаж “чи” гэдэг болох вэ? Түүнтэй “та” гээд яриад сурчихсан, бас хос нэрээр нь нэрлээд дасчихсан. Яаж үнсэлдэж, яаж оронд орох вэ? Өөрийнхөө дотор ямар нэг эргэлт хийх ёстой болно. За яахав, энэ бүхэн хожим болно. Одоо бол Сашагийн тухайд бүрмөсөн тодорхой болгох нь чухал. түүний дахиад хүнтэй суусныг Саша дуулах нь мэдээж. Тэгвэл Софья Александровна л, миний түүнийг хүлээсэн шиг, намайг тэр хүн дөрвөн жил хүлээснийг Сашад хэлэг. Тэгээд хүлээж цөхөөд, намайг хувь заягаа өөрөө шийдэх эрхтэй гэж үзсэн гэж хэлэг.

Игорь Владимировичид зөвшөөрч байгаагаа хэлнэ, гэхдээ эхлээд бүх юмаа түүнд ярина. Костягийн тухай ч, Сашагийн тухай ч. Харин энэ бүхэн бол өнгөрсөн үе, ирээдүй рүү бол

тэрээр Игорь Владимировичтой орно, тэгээд түүний сайн, чин үнэнч, бас, мэдээж, араар нь тавьдаггүй хань нь байна гэж найдаж байна.

Варя байрныхаа талбайгаас Софья Александровнагийн цонх руу харвал гэрэлтэй байв. Унтаагүй байх нь. Варя тэдний рүү өгсөв.

Дасмал гудаа, танил байр. Михаил Юрьевичийн өрөөнд шинэ суугчид орсон, Костя тэр хоёрын нэгэнтээ хөлсөлж асан Сашагийн өрөөд нэг танихгүй хүүхэн сууж байгаа. Варяг хэн юм бэ гэж асуухад, Софья Александровна: “Манай нөхрийн танил” гэсхийн зувчуулж хариулсан. Павел Николаевичийн шинэ гэр бүлийнхний хүн биз, гэвч Варя энэ талаар шалгаагүй.

Олон юм өөрчлөгджээ. Тэглээ ч гэсэн Варя Софья Александровна руу ороод, энэ өрөөтэй өөрийнх нь хичнээн ч явдал холбоотой юм бэ дээ гэж гуниглан бодов: Сашаг эргэх юм эмхэлж, түүний захидлыг уншиж, хариу захианд нь үг дайж, явуулах илгээмжийг нааж энэ тэр гээд, юу эс билээ. Одоо энэ байр түүний хоёр дахь гэр байхаа болино, мэдээж, тэрээр Софья Александровнаг орхихгүй, гэхдээ хуучин шигээ ойрхон ойрхон ирээд байх нь юу л бол. Тэгэхээр Михаил Юрьевичийн бэлэглэсэн ном л ердөө энэ байрны дурсгал болж үлдэх нь.

Варягийн ярьсан юмнаас Софья Александровна бүр сандарчихав.

– Энэ чинь муугаар төгсөж мэднэ. Одоохондоо Мичуринск руу, эгч авгай дээрээ оч, тэгж байтал байдал мэдэгдэнэ.

Тэгж хэлэхээр нь Варя, Игорь Владимирович суух санал тавьсан тухай хэлэв.

– Юун сайн юм бэ, чи чинь түүнийг магтаад байсан биз дээ хэмээн Софья Александровна сэргээд ирэв.

– Тийм шүү, тэр бол журамтай хүн. Тэр ч байтугай, мань хүн шаардаад байхад нь намд элсэхгүй байгаа. Зураг-төслийн газрын дарга мөртлөө нам бус. Тийм хүн өдрийн од шиг цөөхөн.

– Тэр хүн чамайг хамгаалахад бэлэн байгаа нь л миний хувьд хамгийн гол зүйл. Мэдээж, одоо тэр байтугай толгой хийсч байгаа, гэхдээ түүний эрэгцүүлж ярьсан юм надад их учир зүйтэй санагдаад байна, чи түүний хажууд аюулгүй байх нь. Варенька минь суу, өөрийгөө аварч үз. Бас амьдрахад ч чамд арай амар болно.

Варя дуугай байв. Софья Александровна гарыг атгаад, нүд рүү нь харав.

– Чи юунд сэтгэл зовоод байна? Надад хэл л дээ. Сашад уу?

Варя дуугарахгүй байгаа нь түүний таамгийг нотолж буй хэрэг.

– Варенька, хонгор минь... Би Сашад Костягийн тухай ярьж, мэдээж, алдаа хийсэн. Чи өөрөө хэлсэн бол дээр байх байж. Гэхдээ, Варюша, ингэлээ гээд юу ч өөрчлөгдөхгүй л дээ. Саша хагас жил Калининд суусан, одоо Уфад байгаа, надад томилолтоор яваа гэсэн, гэхдээ

Калинин тусгай дэглэмтэй болоод арга буюу явсныг нь би мэдсэн. Уфаг маргааш ч тусгай дэглэмтэй болгочихож мэднэ, тэгвэл дахиад л тэнүүчлэнэ, аягүй бол, цөллөг, хорих газар... Ямар ч гэгээ алга. Саша хар данстай, арга барагдсан хүн, тэрүүн шиг хүнийг ангуучлана. Өөрийнх нь амьдрал эрэмдэг болсон шиг, чиний амьдралыг эрэмдэглэх эрх түүнд байх уу? Хэрэв Саша чиний одоогийн байдлыг олж мэдэх юм бол хормын зуур ч бодолгүй: “Бушуухан суу, тэр тусмаа журамтай хүнтэй ханилах гэж байгаа юм бол” гэж л хэлнэ. Чамд ингэж хэлэхдээ миний гол харлаж байна, чи бол Сашад ёстой сайхан эхнэр байх байсныг би мэднэ, гэхдээ Сашагийн бүх юм нурсан бол, үгүйдээн чиний юм сайн сайхан байг.

Варя дуугүй азнаснаа,

– Сашагийн тухайд таны зөв байж магадгүй. Тэр үнэхээр элдэв хүлээсгүй байх ёстой байх. Гэхдээ би хэзээ ч түүнд дараа болохгүй гэж бодох юм. Игорь Владимирович бол үнэндээ сайн хүн. Гэхдээ би түүнд хайртай гэдэгтээ итгэхгүй байна.

– Варенька, хонгор минь, чи хайр сэтгэлээр суухыг хамгийн сайн гэрлэлт гэж үзэж байгаа юм уу? Чи төөрөлдөж байна... Хайр сэтгэл, бүр хамгийн чин зүрхний амраг хайр ч гэр бүлийн аз жаргалтай амьдралын баталгаа хараахан биш. Би өөрийнхөө нөхөрт, Сашагийн эцэгт ёстой сэтгэл алдсан байсан юм. Манай гэр бүлийнхэн түүнийг дөргүй юм шиг зүтгэдэг, эрс тэс, хүлээцгүй зантай гээд намайг суухад дургүй байсан ч, би тэр занг нь биеэ даасных, нэр төрөө боддогийнх гэж үзсэн. Би хайрандаа сохорчихгүй юү, тэр маань ёстой гоё залуу байсан юм, Варенька. Тэгээд амьдралаа үрчихдэг байгаа. Тэр хүн хувиа хичээсэн, хатуу сэтгэлтэй, амиа хоохойлогч байж таарсан. Хайр сэтгэлээр гэрлэнэ гэдэг чинь энэ дээ! Амьдралаа гагцхүү хүн шиг хүнтэй холбох хэрэгтэй! Жинхэнэ хүнтэй. Игорь Владимирович чамайг дөрвөн жил хүлээж байна гэдэг чинь хайртай гэсэн үг, тэрүүнтэйгээ суу, олон юм бодохын хэрэггүй!

– Намайг таны үгэнд ороосой гэж хүсч байна уу?

– Тэгж байна. Яагаад гэвэл би чамайг аз жаргалтай яваасай гэж хүсч байна.

Маргааш өглөө нь Варя Игорь Владимировичийн өрөөнд орлоо.

Цаадах нь босч, асуусан царайтай харав.

– Игорь Владимирович, өнөөдөр дахиад нэг газар сууя, би танд юмхан ярьж өгмөөр байна.

– Өө, тэгье л дээ, гэхдээ, Варя, та ганцхан үг хэлчих: тийм үү, үгүй юү?

– Тийм.

Глеб тэднийг Хөдөлмөрийн ордны үүдний танхимд угтав. Малилзаад сүйд.

– Саша таныг нааш нь авчрана гэж би мэдэж байсан юм.

– Тийм үү? гээд Лена хариу инээмсэглэв.

– Өөрийнхөө урлагаар гайхуулах гэж.

– Найз гээд байгаа шүү, намайг нэр алдарт дуртай хүн болгож байна гэж Саша халаглаад, – Би чамд төгөлдөр хуурч авчирлаа! гэв.

– Тэр чинь ёстой гайхамшиг! гэж Глеб дуу алдаад, Ленаг хажуудаа суулгав. Тэгээд түүн рүү харан байж, анхныхаа хамсал аяыг дарлаа.

Саша өнөөдөр шиг хэзээ ч ийм баяртай хичээллэж байгаагүй, Глебийн дарж байгаа дассан аялгуу өөрт нь хэзээ ч ингэж нөлөөлж байгаагүй.

тэрээр Ленагийн ярианд ёстой цочирдсон. Гайхалтай давхцал! түүнийг тэгэхэд галт тэрэгний буудал дээр “хар хэрээгээр” авчирсан. Машинаас эхлээд цэргүүд харайж бууцгаасан, харин мань хүн шоронгийн дараа анх чөлөөт хүмүүс, намхан үүл нүүгэлтсэн тэнгэр, нойтон засмал энэ тэрийг хараад сатаарчихсан... Цэргийн дарга: “Бушуул, бушуул, галт тэрэг та нарыг хүлээхгүй, бууцгаа!” гэж хашгарсан. Саша тэгэхэд өөр рүү нь хэн нэгэн харж байх шиг санагдаад, эргэж харсан боловч нэг ч танил царай олж харалгүй, хоёр цэргийн дунд вагон руугаа цааш алхалсан. Тэгсэн чинь Варя түүнийг хараад уйлж байсан юм байж. Салахынх нь өмнө хувь заяа нь тэднийг уулзуулсан атал тэд бие биенээ зэрвэсхэн ч харж чадсангүй. Болсонгүй. Харин хожмоо бол мань хүн өөрөө бүх юмыг нураасан. Түүнтэй утсаар яаж тэгж муухай харьцаж чадсан юм бол! тэрээр түүний: “Саша, чи надад өөр юу ч хэлмээргүй байна уу?..” гээд унтарсан дууг нэхэн санав. Өөрөө түүнд утасдана. Юу гэж ч хариулсан хамаа алга, гагцхүү дууг нь сонсох юм сан, түүнийг үнэлэж байдгийг, өөрөөр нь бахархаж явдгийг, тэр нэгэн ярианы тухайд өөрийгөө зүхэж явдгийг мэдэж аваг...

Глеб хөгжмөө дарсаар.

Саша бүжгээ заан танхимаар явах зуур Ленаг харна, цаадах нь ч өөрийг нь харж, Глебийн наргиа үгийг сонсон инээмсэглэн байна. Саша завсарлага зарлаад, тэр хоёр дээр ирэхэд Ленагийн царай нэлээд тайвширсан янзтай байв.

– За ямар байна, уйдаагүй биз? гэж Саша түүнээс асуув.

– Би мэл гайхчихаад байна!

– Чи надад энэ Глеб шиг хөгжмөөр хамсаж чадах уу?

– Хамсах ий? Юу л бол. Би зөвхөн ноотоор тоглодог юм.

– Ноотны хэрэг юу байна?! Ямар нэг танго санаж байна уу? хэмээн Глеб малилзав.

– Саналгүй яахав. “Оргилуун дарсны хөөс”, “Цуцсан нар”...

Глеб нэг ая дарав.

– Энэ үү?

– Тийм.

мань эр босоод,

– Алив, суугаад тогло доо гэв.

Лена төгөлдөр хуурын ард суугаад, тангоны ая дарав. Даруулаас нүдээ салгаад,

– Би зуун жил төгөлдөр хууранд ойртсонгүй. Ямар байна, дажгүй юу? гэв.

– Маш гоё, ёстой сайхан! гэж Глеб дуу алдав.

– Гадаад хэл гэдэг ганц мэрэгжилтэй гээд байгаа юм даа. Хоёр дахь нь ч байгаа болж таарлаа гэж Саша өгүүлэв.

– Би энийг чинь хэзээ ч мэрэгжил гэж бодож байсангүй.

– Одоо жаахан бод. Дэр мод чирж байхаас арай дээр байх.

Глеб гайхасхийн духаа үрчийлгэхэд, Лена хөмсөг зангидав.

– Хөмсөг зангидах хэрэггүй гэж Саша түүнд хэлээд, – Чиний ямар ажилтайг Глеб мэдэхэд гэмгүй. Энэ бид хоёр чамайг хамсал хөгжимчнөөр ажилд оруулах гэж оролдьё. Ямар вэ, Глеб чадах болов уу? гэв.

– Хичээгээд үзье.

– Бид чамд бас аятайхан байр хөлслөнө, харж хамгаална, чи энэ харь хүмүүст дэндүү гоё хүүхэн.

– Зөвхөн харийнханд ч биш гэж Глеб нэмэв.

Лена бослоо.

– Миний цаг болчихож. Гэр хол, гэтэл маргааш ажилтай.

– Стасик хэзээ ирэх ёстой вэ? гэж Саша Глебээс асуув.

– Найм гэхэд.

– Өө болж байна. Леночка, жаахан тэс.

Саша танхим руу эргэж, алгаа ташив.

– Хичээлээ үргэлжлүүлье. Хоёр, хоёроороо зогсоорой.

Хөгжим дахиад эгшиглэв.

Саша хичээлээ явуулах зуур дахиад Варягийн тухай бодов. Ленагийн ярьсан бүхнийг эрэгцүүлэв: “Тийм залуухан, тийм гоё, гэтэл хамаг амьдралаа бусдад зориулчихсан”. Өөрт нь, цөллөгт байхад нь бас: “Чиний одоо юу хийж байгааг би ёстой мэдмээр байна...” гээд л бичиж байсан. Өөрийг нь ч хайрын сэтгэлээр дэмжихийг хүсч байсан, Ленагийн хүүхдийг ч Алс Дорнод руу аваачсан байна... Гэтэл Глеб тэр хоёр ард түмэн барлаг гээд цуураад байгаа... Үгүй ээ, бүгдээрээ ч арай барлаг биш ээ!..

Стасик хүрч ирээд бас төгөлдөр хуур руу суув. Дараачийн бүлгийн шинэ хүмүүс ирж эхлэв.

Саша сурагчдаа тараагаад, Глеб рүү зэрвэсхэн харав.

– Чи Ленаг дөхүүлж өгөх үү?

– Хэрэггүй ээ, би өөрөө яваад хүрчихнэ.

– Энэ чамайг машинаар хүргэж өгнө, тушаасан газар чинь зогсоод, чамайг буулгачихна.

– Та нар чинь машинтай юм уу?

– Энэ хотын бүх машин манийх хэмээн Глеб инээд алдав.

– Битгий алга болчихоорой. Глеб бид хоёрыг яаж олохоо чи мэднэ. Өглөө бол гэртээ, орой бол энд. Чамайг манай бригадад бүртгүүлэхийг хичээе.

– Би бодох ёстой.

– Бод, гэхдээ битгий нэг их удаарай.

Глеб дараачийн бүлэг хичээлээ дуусч байхад буцаж ирэв.

– За ялдам минь, чамд илтгэхэд байна шүү, тэр чинь газрын тос цэвэрлэх үйлдвэрийн цаана суудаг юм байна, хав харанхуй, хэдэн муусайн байшин, алсад баахан пүнзэн байрнууд, тийшээ явахыг зөшөөрсөнгүй. Би мэдээж: “Таныг ганцааранг чинь явуулахгүй” гэж зүтгэсэн. Пүнзнүүд нь хуаран шиг цуваа юм. Пүнз болгон дэргэдээ шонгийн гэрэлтэй, дотроо бол тас харанхуй, бодвол эрт унтацгаадаг байх, үгүй бол гэрлийг нь тодорхой цагаар асааж унтраадаг байх, бүү мэд. Товчдоо, пүнзэн байрнууд руу дөхөж очтол тэр надтай баяртай гээд түргэн алга болсон, гэхдээ баруун талаасаа хоёр дахь байранд орсныг би анзаарсан.

Саша оройн хоол идэж байхдаа Ленагийн явдлыг Глебт яриу. Ленагийн хувь заяанд өнөө үеийнхээр бол хүн гайхах юмгүй, хаа сайгүй тийм хувь заяа байгаа ч, Глеб анхааралтай сонсов.

– Үгийн төгсгөлийг их тод хэлээд байхаар нь би түүнийг багш гэж бодсон юм.

– Гадаадад удаан суусан, түүнээс хойш тийм болчихсон, дараа нь аль нэг техникийн номын хэвлэлийн газар орчуулагчаар ажиллаж байсан юм.

– Эцэг нь арай гайгүй ажилд оруулчихаж болох байсан байх даа.

– Өө тэгэхгүй, эцэг нь жинхэнэ хүмүүсийн нэг! Лена ч өөрөө тэгж явахгүй. Би ч гэсэн тухай үедээ: улс оронд маань инженер хэрэгтэй гэх маягийн юм бодож явлаа.

Глеб жуумалзан,

– Үзэл сурталтай багачуул байж дээ... гэв.

– Тэр ч яг шүү хэмээн Саша инээд алдав. – Социалист эх орондоо зүтгэхийг хүсцгээж байсан чинь, тэр орондоо хэрэггүй болж таарлаа.

– Тийм сайхан хүүхэн, гурван хэл мэднэ, гэтэл албадан дэр мод чирүүлж байх ч гэж. Нөгөө сайхан хүүхний тухай шүлэг чинь энэ дээ.

– За яамай, дахиад зуу зууг захиал.

– Үгүй ээ ер, өөрөө санал тавьж байх чинь. Юу болчихоов? гэж Глеб гайхав.

– Асуудал байна.

Уугаад даруулцгаалаа.

– Ямар түүх байна гээч, надад нэг хайрт бүсгүй байлаа, бүр Москвад байхад. Юу гэж хэлмээр юм бэ дээ? Хайр дурлал уу? Арван долоотой охин, би түүнд таалагдана, сайн охин, хөөрхөн, ухаантай, ааштай. Дараа нь намайг шоронд хийчихлээ, тэр бүсгүй шоронгуудаар явна, надад эргэлт зөөнө, ээжийг маань харж хандана, цөллөгт байхад надад захиа бичнэ, би ч хариу бичнэ, уулзана гэж мөрөөдөнө, нэр нь Варя. Тэгээд эргэж ирээд, энэ хооронд түүний хүнтэй суусныг олж мэдлээ, гэхдээ дорхноо салсан юм байж. Гэхдээ л тархиар татаад авах шиг болж, би, мэдээж, тас огтлолгүй яахав, харилцаагаа. Тэгтэл хэрэг дээрээ юу болсныг Лена ярьж өгөөд, бүх юм шал өөрөөр эргэдэг байгаа даа, ярьж барах юм биш. Нэг үгээр, миний буруу байж, түүнийг шудрага бусаар, бүдүүлгээр үгүйсгэсэн юм байна, тэр намайг хүлээж байсан байхад би түүнийг хөсөр хаяжээ.

– Чи хайртай байсан уу?

– Хайртай байсан.

– Одоо бол?

– Одоо ч гэсэн хайртай.

– Тэгвэл тэр чинь?

Саша дал мөрөө хавчив.

– Мэдэхгүй, таван жил уулзаагүй.

– Бодлого оо бодлого... хэмээн Глеб сунжруулан өгүүлэв.– Залуухан охин, чамайг, мэдээж, өчнөөн жил хүлээгээд пийшин дээр хэвтэж байхгүй. Гэтэл нөгөө талаас, анхны хайр! Энэ чинь бас мартагддаггүй юм, ялдам минь.

– Түүн рүү утасдана аа гэж Саша өгүүлэв.

– Зүйтэй. Нааш нь дуудаад аваад ир. Зочид буудалд хамгийн сайн өрөөнд оруулъя. Тэгээд та нар учир явдлаа олцгооно биз.

– Ажилтай, сургуультай хүн чинь яаж наашаа ирэх билээ?

– Майн баяр юу юугүй болох гэж байна, бас хоёр гурван өдөр амралтаасаа авчихна биз, тэгээд л бал сар болчихно. Үүний төлөө уух хэрэгтэй, ялдам аа!

Аятайхан санаа! Бас Лена ч Уфад байгаа. Варяд: “Баяраар бидэнд дээр ир! Цөмөөрөө уулзацгаая” гээд хэлчихнэ.

– Одоо Ленагийн тухайд. түүнийг бидний энд төвхнүүлэх хэрэгтэй байна, энэ муухай дэр модтой балрана.

– Тэгэх хэрэгтэй хэмээн Глеб санал нийлэв. – Лена, Стасик хоёрыг заавал ятгана, зайчлая. Цөлөгдсөн хүн гээд Машка хавьтуулахгүй болов уу гэж эмээж байна.

– Каневский бас цөлөгдсөн хүн, гэхдээ манайд ч ажиллаж байсан, одоо эндхийн найрал хөгжимд байгаа. Овог уу? Машка тийм овгийг мэдэхгүй ч байж магадгүй, улс төрийн хувьд тэгтлээ боловсролтой биш байх.

– Тэгж саная. Тэгвэл Семён? Дахиад л төгөлдөр хуурч хэрэггүй гэнэ дээ.

– Семёнийг дургүйцвэл би маргааш хамаг юмаа хаяад, яваад өгнө.

– Бүр тэгэхдээ хүрэх үү?

– Бүр тэгэхдээ хүрнэ. Тэр тухайд бол бодоод ч байх юм байхгүй.

– Хөөе ялдам аа, би бодож байгаа юм биш, яаж баараггүй хийх талаар эрэгцүүлэн цэгнэж байна. Огцроно гэдэг чинь зөв нүүдэл. Сашка явах юм бол би ч явна гээд би бас нэмчихнэ.

Саша Москва руу ер нь бол бүтэн сайнд утасддаг. Гэтэл бүтэн сайн хүртэл гурав хоног байна. Төчнөөн хүлээхийг сэтгэшгүй. тэрээр маргааш нь Варя руу утасдлаа.

Холбооны хүүхэн захиалга авахдаа,

– Утас авсан хүнтэй юү, эсвэл хэн нэгнийг дуудуулах уу? гэж асуув.

– Варвара Сергеевна Ивановаг.

– Хүлээж байгаарай.

Дараа нь,

– Гэртээ алга байна гэв.

Маргааш нь энэ байдал яг давтагдлаа. Сургууль дээрээ байгаа байх.

Бүтэн сайнд эхлээд ээж рүүгээ утасдав. Ээж нь хуучин янзаараа утас дуугарахыг хүлээж байж. Сайн уу, бие ямар байна... Ярианыхаа төгсгөлд,

– Варя яаж шуухан аж төрж байна? гэж асуув.

Тэгэнгүүт ээж нь түгдрээд явчихыг гэнэт мэдэрлээ.

– Варя юу, Варя хүнтэй суусан, Сашенька.

– Хүнтэй суусаан?

– Тийм ээ. Сайн хүнтэй, журамтай хүнтэй. Тэр хоёр олон жилийн танилууд, гэхдээ бүх юм ганцхан өдөр шийдэгдсэн. Нөхцөл байдал тийм болж таарсан. Чи намайг ойлгож байна уу?.. Тийм цаг үе, Сашенька, надаар хэлүүлэлтгүй чи мэдэж байгаа хойно.

– Хэзээ тэгээ юм бол?

– Хагас сарын өмнө.

– За тийм байж. Намайг баяр хүргэж байна гээрэй. Чин сэтгэлийн угаас, үнэн санаанаасаа, халуун дотно баяр хүргэж байна гээрэй.

Хоёрдугаар хэсэг

1

Глебт сонин мэдээ иржээ. түүнийг театрын зурагчин гэдгээ нотолсон бичиг баримтаа авчир гэж Мария Константиновна тушаажээ:

– Москвагаас нэхсэн, танд театр хайж байгаа юм байна.

– Чиний Ульяна ажиллаж байгаа хэрэг гэж Глеб Сашад хэлэв.

Саша ярвайв. Ульянаг сануулмагц дотор нь ширхийгээд явчихаж. Юуны чинь “чиний” Ульяна!..

– Ямар нүх надад санал болгохыг нь харья л даа. Харин энэ зуур бол Ленаг төвхнүүлэх хэрэгтэй байна.

Семён Григорьевич, бүлгүүд дуусч байна, сар-сар хагасын ажил л үлдсэн гээд шинэ хамсал хөгжимчний тухай сонсох ч дургүй байж. Харин Саша, Глеб хоёрыг явна гэж айлгамагц буулт хийжээ. За яахав, тэр танилыг чинь тоглохыг сонсоё, тэгээд шийдье гэж.

Гэтэл Лена үзэгдэхээ больчихож.

– Хоёулаа түүн дээр очъё, аль байшинд орсныг нь би харсан гэж Глеб санал болгов.

– Тэр чинь чи бид хоёрыг очуулах дургүй байгаа. Харзняя.

Лена хоёр долоо хоногийн дараа Хөдөлмөрийн ордонд ирэв.

– Амралтын өдөр ч ажиллаад.

Бүлэгтэйгээ хичээллэж байсан Саша түүнийг хараад гар даллан мэндлэв.

Глеб баярлан малилзаж, Ленаг дахин хажуудаа суулгаад, яаж хөгжимдөхийг дахин харуулж, тэр ч битгий хэл, өөрийнхөө оронд нэг хэсэг албадан хөгжимдүүлэв. Дажгүй болоод байх шиг.

Саша завсарлагаанаар тэдэн дээр ирж, Ленаг мөрөөр нь тэврэв.

– Бид бүх юмыг ярьж тохирсон. Глеб чамайг бага зэрэг дасгалжуулна, дараа нь чи удирдлагад

өөрийнхөө урлагийг үзүүлнэ. Гол нь хаана зогсогнох, хаана давтахаа ойлгох явдал, энэ бүхэн яваандаа гарт чинь орно.

Лена санаанд оромгүй татгалзав:

– Баярлалаа, залуус минь. Энэ чинь надад даанч таарахгүй нь.

– Яагаад тэр билээ?! хэмээн Саша бүр гайхаж хоцров. – Чамайг арай дээр ажилд шилжүүлээ юү?

– Ажил хэвээрээ байгаа. Гэхдээ надад болоод байгаа юм. Найдвартай. Ажилчин хэзээ ч хэрэгтэй. Ялангуяа дэр мод зөөх ажилчин. Танай энд бол найдвартай биш. Өнөөдөр та нар энд байна, маргааш байхгүй болчихно. Би юутай үлдэх вэ?

– Аялан тоглогчдын товчоонд оруулъя. Янз бүрийн дуучид ирдэг юм, тэдний концертод хамсал хөгжим хэрэгтэй.

тэрээр толгой сэгсрэв.

– Үйлдвэрт намайг хэн ч анзаарахгүй, харин энд бол ил байх нь. Концертод хамсан хөгжимдөх үү? Тэгэхээр миний нэр зарлал дээр гарна гэсэн үг. “Төгөлдөр хуурч Е. Будягина”, тэгж бичдэг биз дээ?

– Одоо бол манайд ажиллах тухай ярьж байна, дараа нь байдал мэдэгдэнэ.

– Сашенька, надад ганцхан юм л мэдэгдэж байна: энд миний байх хугацаа тун бага үлдсэн. Чи ойлгож байна уу?

– Лена, би бас таныг ойголоо гэж Глеб хөндлөнгөөс оролцов. – Гэхдээ байдал өөрчлөгдөж байна шүү дээ. “Ежовын бээлий” нэгэнт байхгүй боллоо, Ежовыг өөрийг нь шоронд хийсэн гэгцгээж байна. Бас зарим нэг хүнийг суллаж байна, цагаатгаж байна.

– Магадгүй, магадгүй хэмээн Лена доогтой өгүүлэв. – Хэрэв намайг бас чөлөөлөх юм бол, надад нэг ажлаас нөгөө рүү харайлгаж явахын хэрэг юу байхав? Хүлээе, миний эцэг эхийг ч бас Москва руу буцаах ч юм бил үү?

түүний доог ойлгомжтой. Ямар цагаатгал вэ?! Хэдхэн генерал сулласан юм шиг, шоронд хийх нь цөөрсөн юм шиг сураг төдий юм дуулдсан, гэтэл хүн амынхаа хагасыг шоронд хийчихсэн юм чинь үлдсэн хагасыг хийгээд эхлэх юм бол хэн үлдэх вэ, нөхөр Сталин хэнийгээ удирдах вэ? Лена хэрсүү ярьж байна. Үйлдвэрт байхад анзаарагдахгүй гэдэг бол өнгөц зүйл, түүнийг мэдэх ёстой хүмүүс нь мэдэж байгаа. Гэхдээ анзаарагдахгүй байгаа юм шиг байдал эрхиш байгаа, тэр нь түүнийг тайвшруулж байна.

– Чи юу гэж үзэж байна, түүгээрээ шийд, би бол үнэнийг хэлэхэд, чамайг баярлана гэж бодож байсан юм. Үгүй гэж байгаа бол яая гэхэв, ямар ч байсан манай руу ирж бай. Битгий удаан алга болчихоод байгаарай гэж Саша хэллээ.

Глеб Лена руу гунигтай харав.

Сэтгэл алдчихсан юм уу, хаашаа юм?!

Лена тэр хоёр дээр амралтынхаа өдрүүдээр ирдэг болов. Глебтэй зэрэгцэн суугаад, заримдаа түүний оронд зүгээр л өөрийн урам болгож хөгжим дарна.

түүнийг ирэхээр Глеб сэргэж, бүр эвийлж ахайлаад явчихна. Саша түүний тийм байхыг хэзээ ч үзээгүй, цаанаа л нэг төлөв, хөгжүүн хөхиүн оргиод, Лена руу хараа шидлэн, баяртай малилзана.

Дараа нь тэд Ленаг дөхүүлж өгнө, заримдаа хоёулаа, ихэнхдээ Глеб ганцаараа дөхүүлнэ, тэр хооронд нь Стасик түүнийг орлоно, Сашаг орлох хүн даанч байхгүй.

Нэг удаа, яг Ленагийн амралтын өдөр нэг бүлгийнхний ажлын газар яаралтай цуглаан хийх болсон учраас хичээлээ хойшлуулжээ.

– Ресторанд орж жаахан сууцгаах уу? гэж Глеб санал гаргав.

Лена дал мөрөө хавчин,

– Би бол кино үзвэл үзчихмээр байна. Ирэх замдаа та нарт “Правда” худалдаж авсан, Эйзенштейн “Ленин 1918 онд” гэдэг Роммын сүүлчийн киног магтсан байна гэв.

– Гоё санал, кино үзэцгээе гэж Глеб түүний амыг дагуулав.

Зургаан цагийн билет авцгааж, Саша арайхийн киног дуусгав. Сталиныг магтах ч яахав, дүүрсэн хэрэг, одоо бүгдээрээ тэгцгээж байгаа юм чинь. Гэтэл Лениний аминд халдахад Бухарин дөхөм үзүүлж байгаа хэсэг бүр ой гутмаар, үүнээс бузар юм гэж юу байх вэ. Саша Бухариныг нэг удаа Хамовникт, пионерийн чуулган дээр харсан, Бухарин тэнд үг хэлж, түүнийг хүндэт пионер болгож байсан билээ. Ямар ч хамгаалалтынхан энэ тэр байхгүй, хүүхдүүдтэй хөгжилдөн гудамжаар явж байгаад, хүлээж байсан машиндаа суусан. Ленин түүнийг “намын хайрт хүү” гэдэг байсан. Гэтэл түүнийг урвагч, тагнуул, алуурчин гээд буудан алсан. Тэгсэн чинь найруулагч Ромм хэмлүүлсэн Бухариныг дэвсчих гэж яарч байдаг байна.

Тэр гурав киноноос гарч, автобусанд сууцгаав.

Автобусаар явж байхдаа, Саша нөгөө “Правда”-г нь авч үзэв.

“Энэ кино сэтгэл зүрхэнд хүрч байна, большевизмын агууг илтгэж байдаг хүмүүнлэг үзлийн амин сүнсийг энэ кино барьж авч чадсан байна... Баатруудынх нь янз бүрийн араншин, янз бүрийн үйлдэлд хувьсгалын хүнлэг чанар, түүнийг гардан хийгчдийн агуу их хүмүүнлэг үзлийн сэдэв нэвт шингэсэн байна...”

Эйзенштейн бас тийшээ нийлчихэж! Саша хүүхэд байхдаа түүний “Хуягт Потёмкин”-ийг үзсэн. “Хуягт Потёмкин”-ийг хамгийн сайн кино, Эйзенштейнийг аугаа их кино найруулагч

гэж дэлхий хүлээн зөвшөөрч байсан. Одоо энэ “аугаа их” маань харгис дарангуйлагч, алуурчинд үнэнчээр зүтгэж байна. Энэ бол Глеб тэр хоёрын суу билэгтэн, хорон санаат хоёрын тухай мэтгэлцээний нэгэн бодит зураг.

Глеб сонинг уншаад Саша руу харж,

– За тэр дээ, бас нэг барлаг гэв.

Глеб ч бас нөгөө яриагаа санасан байх нь.

Ленаг ирж байгаад Саша баяртай байлаа. Бага, залуу насны гунигтай, баяртай, сэтгэл гөхөлзүүлсэн янз бүрийн дурсамж хөврөнө. тэрээр Ленаг хараад байн байн: Иван Григорьевичийн цус гэдэг энэ дээ! гэж бодно. Өөрийг нь өнөө маргаашгүй баривчлана гэж мэдэж байгаа хэрнээ тэр тухай ганц үг ч дурсахгүй.

Ленагийнхийг бодвол өөрийнх нь байдал хавьгүй хөнгөн байсан, чухамхүү гэнэтхэн баривчилсан учраас тэр. тэрээр: “Энэ бол миний эрх чөлөөтэй сүүлчийн алхам” гэж бодох юм бол яаж сургууль руугаа явах, яаж анд нөхөдтэйгөө уулзах, яаж идэж уух энэ тэрээ ёстой төсөөлөхгүй байв. Тэгэхээр Ленагийн байдал бол чухамдаа эрүүдлэг! Хүүгийнх нь тухайд ч эрүүдлэг! Хүүтэйгээ хэзээ нэгэн цагт уулзах найдваргүйгээр салах ёс хийсэн байж ч магадгүй. Ганц тайтгарах юм нь энд тэгтлээ ганцаардаагүй, Глеб тэр хоёр хань болж байгаа, Москвад ч гэсэн Варя хань болж байж.

Варяг дахин гэрлэсэн тухай мэдээг Саша хатамжин байж давав. Ямар ч байсан өөрт нь тэгж санагдаж.

– Нөгөө Варя чинь юу болсон бэ, тэр чинь ийшээ Уфад ирэх юм уу, үгүй юм уу? гэж Глеб асуув.

– Варя хүнтэй суусан байна. Тэр хүнээ олон жилийн турш мэддэг юм байж, гэхдээ уг асуудал ганцхан өдөрт шийдэгдсэн гэнэ. Тэгсэн нь ч дээр болсон байж магадгүй.

Түүнтэй амжиж ярьсан бол чухамдаа юу өөрчлөгдөх сөн билээ? Яахав уулзацгаасан байх юм биз. Өөрөө түүнд юу гэж ч хэллээ гэсэн, Варя өөрт нь юу гэж ч хариуллаа гэсэн, тэртэй тэргүй мань хүн түүний амьдралаас алга болох ёстой. Харин одоо бол өөрийнх нь амьдралаас тэр алга болсон болж таарлаа. Варя зөв хийсэн байна: мань хүн сайн бол тэнүүчлэн амьдрана, муу бол хорих газар хүлээж байгаа. Тийм учраас тэртэй тэргүй өөрийг нь хүлээж тэсэхгүй. Шинэ нөхөр нь өөр шиг нь хүн амьтанд тус болдог, тэр нь тэр хоёрыг ойртуулсан байж магадгүй. Уучлал гуйж амжаагүй маань л харамсалтай. Одоо утасдах юм уу? Тэнэг хэрэг болно, утасддаггүй, захиа бичдэггүй байснаа, хүнтэй суусныг дуулаад гэнэт гарч ирж, баяр хүргэж, өнгөрсөн явдлын тухайд уучлалт гуйна гэдэг чинь юу гэсэн үг вэ. Хэзээ нэгэн цагт түүнтэй таарч мэдэх юм, тэгвэл уучлалт гуйж болох.

Мэдээж гуниг, гэвч яалтай нь билээ?! Бас өмнө маань юу байна вэ? Уфагийн дараа хаачих вэ? Семён Григорьевичийг дагаад Саратов руу сажлах уу? Глебтэй хамт явбал ч бас яахав гэх сэн, үнэнч нөхөр маань юм чинь. Рязань явдаг юм уу? Талийгаач Михаил Юрьевичийн ах надад

юугаар туслах вэ? Рязаньд ямар ажил хайх вэ? Бүх юм манан дотор байна. Өөрийгөө голохоос дургүй нь хүрээд байв. Цөллөгт байхдаа франц хэл үзэж байсан, Францын хувьсгалын түүхийн тухай найруулал бичиж байсан, бичсэн юм, сурах бичиг энэ тэр нь энд чемодан дотор нь хөглөрч байгаа, тэдгээрт нэг ч удаа гар хүрээгүй, ганц ч ном уншсангүй. Бүжиглэж байна, балгаж байна. Амьдрал нь ердөө ийм л юм болсон байна.

Гитлер Европт хамгийн хүчтэйн нэг болох Польшийн армийг хоёр долоо хоногт бут ниргэж, Финляндаас арав дахин олон хүн амтай улсыг буулгаж авлаа. мань ХҮН зөвлөлтийн ард түмнээс дөч дахин цөөн ард түмэнтэй гурван сар гаруй байлдаад дийлсэнгүй. Цэргийнхэнд итгээд, финнийн эсэргүүцэх хүчийг дутуу үнэлжээ. За яая гэхэв, улс төрч болгонд бүтэлгүйтэх юм гардаг, ямар ч жанжин заримдаа ялагдал хүлээдэг.

Харин ард түмэн бол өөрийнх нь арми ялагдашгүй гэдэгт урьдын адил итгэж байх ёстой, бид зөвхөн бусдын нутаг дээр байлдана гэдгийг мэдэж байх ёстой, сая бид зөвхөн финнийн нутаг дээр байлдсан, бас бид бага цусаар ялж ирсэн, хойшид ч тэгнэ гэдэгт итгэл төгс байх ёстой. Тийм учраас манай гарз хохирлын тухай мэдээлж болохгүй. ЗСБНХУ бол том улс, тэгэхээр тоо томшгүй олон хот суурин, тосгон гацаанд хэд гурван хүн дутвал, бидний үнэн хэрэгтээ хичнээн хүнээ алдсаныг хэн ч олж мэдэхгүй. Ард түмэн: ЗСБНХУ Финляндтай залгаа хилээ гучин хоёр километрээс зуун тавь хүртэл холдуулсан, тэгснээрээ Ленинград хотын аюулгүй байдлыг хангасан гэдэг ганцхан юмыг л мэдэх ёстой.

Ард түмэн бас Европт дайн болж байгааг мэдэж байх ёстой. түүний хүчин чармайлтын үр дүнд Зөвлөлт Холбоот Улсын хувьд энх тайван сахигдаж байна. Найдваргүй, хэврэг энх тайван. Хэрэв ЗСБНХУ хэн ч довтолж зүрхлэхгүй, дэлхийн хамгийн хүчирхэг орон болж хувирах юм бол энэ энх тайван найдвартай, бат бэх болно. Үүний тулд улс орны эдийн засгийг цэргийн гольдролд оруулж, онгоц, танк, шинэ зэвсгийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хэрэгтэй. Энэ бол их хүч, олон золиос шаардана, гэхдээ ард түмэн энх тайвныг, амар амгалан байдлыг хүсч байгаа бол энэ бүхнийг гаргах ёстой. Хөдөлмөрийн хатуу чанд сахилга тогтоох хэрэгтэй, зөрчигсдийг маш хатуу цээрлүүлж байх хэрэгтэй. Армид төмөр мэт хатуу дэглэм, нэг хүний удирдлагын тогтолцоо тогтоож, генерал, адмиралын цол бий болгох хэрэгтэй. Ворошиловыг батлан хамгаалах ардын комиссарын үүрэгт ажлаас чөлөөлж, оронд нь Тимошенког томилох. Финляндад бүтэлгүйтсэний буруутнаар цэргийн тагнуулын газрыг зарлах. Улаан Армийн Тагнуулын газрын дарга Проскуровыг буудан алах.

Олон улсын нөлөө тусгал? Муу, ашиггүй нөлөө тусгал гарна. Гэхдээ энэ бол түр зуурын хэрэг. Зөвлөлт Холбоот Улс жинхэнэ хүчээ харуулахдаа нэг харуулна. Гитлер Англи, Франц хоёрыг дарсан цагтаа Зөвлөлт Холбоот Улстай байлдана, хоёр фронт дээр зэрэг байлдаж чадахгүй. Тэгвэл Франц, Англи хоёр бол Польш биш, хоёр долоо хоногт тэднийг гэтлэхгүй. Энэ хугацаанд тэрээр дэлхийн хамгийн хүчирхэг цэргийн аж үйлдвэр, хамгийн хүчирхэг армийг байгуулна.

Англи, Франц хоёр финнүүдэд туслаж, зэвсэг явуулж байсан, нүүдлийн цэрэг зохион байгуулсан, бүх Европоос сайн дурынхан Финляндад ирж байсан. Ийм нөхцөлд байлдааны үйл ажиллагааг үргэлжлүүлвэл Англи, Францтай хийх дайн болж зайлшгүй хувирах байсан. Үүнийг Гитлер хүсч байсан, ЗСБНХУ-ыг өөрийнхөө талд дэлхийн хоёрдугаар дайнд татан оруулахыг хүсч байсан. Гэвч Зөвлөлт Холбоот Улс тийм дайнд хараахан бэлэнгүй байгаа. тэрээр өөрөө бэхжиж, тэднийг сульдсан цагт босно. Чухамхүү ийм учраас тэрээр байлдааны ажиллагааг зогсоож, финнүүдтэй эвийн гэрээ байгуулсан.

Тийм шүү, чухам ийм учраас байгуулсан, өөрөөс нь тэнэг биш гэдгээ Гитлерт харуулсан, тэгээд Гитлер ЗСБНХУ-ыг дайнд татан оруулж чадахгүйгээ, өөрөө байлдахаас өөр аргагүйгээ ойлгосон. Тийнхүү байлдаж байна. Германууд дөрөвдүгээр сард Данийг эзэлсэн, Норвегт цэргээ оруулсан. Тавдугаар сарын эхээр Голланд, Бельги хоёр бууж өгсөн...

Тавдугаар сарын 24-нд Берия тун сая Нью-Йоркоос авсан цахилгаанаа илтгэв. “Ажилбар хэрэгжсэн. Үр дүн нь арай хожуу тодорхой болно”.

Ийнхүү Троцкийд хүрчихэж. Гэтэл яахаараа “үр дүн нь арай хожуу тодорхой болно” байдаг билээ? Тэр новш алагдсан юм уу, үгүй юм уу?

Энэ асуултын хариуг Сталин арга буюу хэд хоног хүлээв. Тэгж тэгж Берия хүрч ирэв. Байж байгаа царайгаар нь, нүдээ хавчдаг шилнийхээ ард нууж байгаа байдлаар нь, хоолой нь чичирч байгаагаар нь Сталин ажилбар баларсныг ойлгов.

Сталин Берияг муухай харах зуур,

– Илтгэгтүн! гэв.

Берия илтгэв.

– Ажилбарыг алдарт зураач Сикейросын удирдлагаар явуулсан. Автомат, пулемётоор зэвсэглэсэн хорин хоёр хүнтэй бүлэг шөнийн гурван цагт Троцкийн байшин руу очиж, гаднах хамгаалалтыг хоромхон зуур устгасан. Том хаалган дээр жижүүрлэж байсан манай хүн хаалга онгойлгож өгсөн. Сикейросын хүмүүс дотоод хамгаалалтынхны зэвсгийг хураан гарыг нь мухарлаад, Троцкийн унтлагын өрөөний хаалга, цонх руу шуурган гал нээсэн. Пулемёт шууд онилж байгаад, хоёр зуу гаруй сумаар шүршсэн. Ажилбарыг дуусгамагц, төгсгөлд нь нэг бөмбөг шидчихээд, бүлэг арилаад өгсөн. Гэтэл...

Энд Бериягийн дуу гарахаа больчихов.

– Юун “гэтэл” гэж Сталин зандран асуулаа.

– Троцкий, авгай хоёр орныхоо ард нуугдчихсан чинь ор нь тэдний халхавч болсон байна. Хажуугийн өрөөнд байсан тэдний ач хүү л жаахан шалбарч өртсөн гэнэ.

Сталин босч өрөөн дундуураа нэг тийш хэд алхав. Берия ширээний ард хөдөлгөөнгүй суугаад түүнийг ажиглаж байв.

Сталин эргэж харалгүй,

– Унтлагын өрөө нь том юм уу? гэж асуув.

– Том биш...

– Жижгэвтэр өрөө рүү буудсан хоёр зуун сум энэ өрөөнд байсан хүмүүсийг шүргэсэнгүй гэж та надад батлахыг хүсч байна уу?

– Нөхөр Сталин...

– Би бол нөхөр Сталин гэдгийг би мэднэ! Би танаас асууж байна: ингэж яаж чадсан юм бэ? Хоёр зуун сум, тэгээд нэг нь ч оносонгүй?

– Цонх, ор хоёрын хооронд хагас метрийн зайтай. Авгай нь Троцкийг тийш нь түлхчихээд, дээрээс нь хэвгчихэж. Цонхноос ор руу, бас бүх өрөөгөөр нь буудаад байж, гэтэл тэдний нуугдсан зай яалт ч үгүй битүү нуувч шиг болчихож.

Сталин буцаж ирж ширээ рүү суугаад, Берияг дахин муухай харав.

– Тэгвэл нөгөө бөмбөг?

– Бөмбөг тэсэрсэнгүй.

Сталин ширээ шаав. Царай нь хүн харахын эцэсгүй аймшиг.

– Хэн нь хэнийгээ хуурч байна вэ?

Берия дуугарсангүй.

Сталин дахин ширээ шаав.

– Хэн нь хэнийгээ хуурч байна вэ гэж би асууж байна. Сикейрос Эйтингоныг, Эйтингон Берияг үү, эсвэл Берия нөхөр Сталиныг хуурах гэж оролдож байна уу?

Берия дуугарсангүй.

– Яагаад дуугай байна? гэж Сталин хашгарав.

– Нөхөр Сталин, Троцкийн хүрээлэлд манай хүн нэвтэрсэн. Таны даалгавар биелэх болно гэж Берия өчив.

– Хэзээ?

– Ойрын үед.

– За тэгвэл, та нарт гурван сарын хугацаа өгье, наймдугаар сард бүх юм дууссан байх ёстой. Үүнийг Судоплатов, Эйтингон нарт дамжуулаарай. Ташрамд хэлэхэд, тэдэнд Шпигельгласын тавиланг сануулаарай.

Зургадугаар сарын 6-нд Москвад суугаа Английн шинэ элчин сайд Стаффорд Криппс Черчиллийн хувийн илгээлтийг Сталинд дамжуулав. Черчилль, Гитлер Европын бүх улсыг, түүний дотор ЗСБНХУ-ыг буулгаж авахыг эрмэлзэж байна гэж анхааруулаад, хамтран ажиллахыг санал болгожээ.

Сталин илгээлтийг уншаад,

– Би Германы хэд хэдэн удирдах зүтгэлтэнтэй сайн танил, тэдэнд Европын улсуудыг залгих эрмэлзэл байгааг анзаараагүй гэж хариулав.

Энэ яриа болон Черчиллийн илгээлтийн бичвэрийг тэр өдөртөө Гитлерт уламжилжээ. Сталин Гитлерийн талаар төвч байр сууриа тийнхүү харуулав.

Долоо хоногийн дараа, зургадугаар сарын 14-нд германууд Парисыг эзлэв.

Энэ мэдээ Сталины гайхшийг баржээ. Европын хамгийн хүчтэй гүрний нэг Франц сарын дотор унажээ. Гитлер ялагдашгүй хэрэг үү? Гитлер үнэхээр түүнийг хуурна гэж үү?

Францыг ялсанд зориулж рейхстагт үг хэлэхдээ Гитлер,

“Энэ мөчид миний сэтгэлийн жудаг надад Их Британийг эрүүл саруул ухаанд уриалан дуудахыг тушааж байна, учир юун хэмээвээс, би бол өмгөөл ивээл царайчилж байгаа ялагдсан дайсан биш, би бол ялагч... Черчиллийн Канад руу зугтахыг хүлээхийн хэрэггүй, Германтай одоо энхийн хэлэлцээ хийж эхлэх хэрэгтэй” гэж мэдэгджээ.

Английн хариуг Сталин Гитлерээс дутуугүй сэтгэл догдлон хүлээж байв. Францыг хоромхон зуур ялсны дараа Англитай эв зүйгээ олвол Гитлер Европын эзэн болж, түүний хамаг тооцоог нураана.

Хэд хоногийн дараа Английн гадаад хэргийн сайд Иден Гитлерийн эвийн тухай саналыг няцаав. Наймдугаар сарын 13-нд германууд Английн хотуудыг бөмбөгдөж, Английн дээр агаарын тулалдаан эхлэв. Англичууд Гитлерийн энэ үйлдлийг хэзээ ч уучлахгүй нь мэдээж. Сталин амсхийн санаа алджээ.

Наймдугаар сарын 21-ний орой Берия яаралтай мэдээтэй ирэв: өнөөдөр Мехико хотын эмнэлэгт Троцкий нас барсан байна. ДЯАК-ын Койоаканд нэвтрүүлсэн агент, өнгөрсөн удаа Бериягийн түүнд илтгэж асан нөгөө испани Рамон Меркадер аялагчийн мөсний сүхээр Троцкийн толгойг хага цохьсон аж. Ажилбарыг Мексикт Эйтингон, Москвад Судоплтов нар тус тус удирджээ.

Заяагүй золигийг цааш нь харуулж дээ! Гучин таван жил энэ хүн түүний амьдралыг хордуулж, түүний эгдүүг хүргэсэн. тэрээр түүнийг 1905 онд Лондонгийн их хурал дээр уран цэцэн үг хэлсэн мундаг амьтан байхад нь анх удаа харсан, тэгэхэд мань ХҮНИЙГ ердөө анзаараа ч үгүй. 1913 онд Троцкий Венад бас мундаг үг хэлж, олны анхаарлын төвд байсан, түүнийг бас л анзаараагүй. Арван долоон онд хувьсгалын удирдагч, жолоодогчийн дүрд тоглосон, иргэний дайны үед өөрийгөө ялалтын гол зохион байгуулагч гэж үзээд, түүнийг юман чинээ тоохгүй, их зан гарган, шижээргүй царайлж байсан. Тэгвэл сүүлийн арван таван жил түүнийг угаадсаар булж, хаа сайгүй шившгийг нь хутгасан, тэр ч бүү хэл, түүний тухай ном бичсэн, даанч нийтэлж амжаагүй гэлцдэг. Тэр номонд юуны тухай бичсэн нь тодорхой: Троцкий бол суу билэгтэн, харин Сталин бол хэр тааруу амьтан гэсэн байгаа. Үгүй шүү! Нөхөр Сталин ертөнцийн хувь заяаг шийдэж байгаа, харин ноён Троцкий гавлаа хага цохиулчихаад, хүүр хадгалах газар новширч байгаа. Хохь нь, очих газар нь тэр.

Берия түүнд, Сикейросын халдлагаас өмнө, хоёрдугаар сард бичсэн Троцкийн гэрээсийг бас гардуулав. Заяагүй золиг, өр төлөөснөөс мултрахгүй гэж ойлгож байж, тэгээд үхлээ зөгнөж байж. Гэхдээ алив бусад хүн шиг мөрөөрөө үхэж чадсангүй. Авсны ирмэг дээр байхдаа ч томроод байсан. За яахав, энд юу гээчийг бичсэнийг нь харъя.

Сталин Бериягийн өгсөн хавтсыг нээв,

Гэрээс

Тайлал ойрхон ирсэн бололтой. Эдгээр мөр миний үхсэний дараа нийтлэгдэнэ.

Надад энд Сталин болон түүний тагнуулын албаны мулгуу бөгөөд шившигтэй гүжирдлэгийг няцаах ямар ч шаардлага алга: миний хувьсгалч нэр төрд нэг ч толбо байхгүй. Би ажилчин ангийн дайсантай ар худраганы ямар ч яриа хэлэлцээ, тохиролцоонд шууд буюу дамаар хэзээ ч орж яваагүй. Сталины мянга мянган эсэргүүцэгч тийм хуурамч яллагааны золиос болж амь насаа алдсан. Хувьсгалт шинэ үеийнхэн тэдний улс төрийн нэр төрийг сэргээж, Кремлийн алуурчдад зохих зэмийг нь хүртээнэ.

Миний амьдралын хамгийн хүнд хэцүү цагт надад үнэнч хэвээр үлдсэн анд нөхөддөө би халуунаар талархаж байна. Би бүгдийг нэрлэж чадахгүй учраас хэнийг ч тухайлан нэрлэхгүй байна.

Гэхдээ би өөрийн найз Наталья Ивановна Седоваг үүнд үл хамааруулах эрхтэй гэж өөрийгөө үзэж байна. Социализмын үйл хэргийн төлөө зэрэгцэн тэмцэх аз завшааны хажуугаар түүний нөхөр байх аз завшааныг хувь заяа минь надад хайрлажээ. Бидний хамт амьдарсан бараг дөчин жилийн турш тэр маань энэрэл хайр, уудам сэтгэл, энхрий ялдамын ширгэшгүй ундрага болж ирсэн юм. Тэр маань ялангуяа манай амьдралын сүүлийн хэсэгт ихээхэн зовлон зүдгүүр амссан. Гэхдээ аз жаргалтай өдрүүд түүнд бас тохиож байсан хэмээн би сэтгэлээ зогоож байна.

Би ухамсарт амьралынхаа дөчин гурван жилд нь хувьсгалч байж, түүнээс дөчин хоёр жил нь марксизмын тугийн дор тэмцэж ирлээ. Хэрэв би дахиад шинээр эхлэх ёстой болсон бол, наадах цаадах алдаанаас зайлсхийхийг, мэдээж, хичээх байсан, гэхдээ миний амьдралын ерөнхий чиглэл хувирахгүй, тэр чигээрээ үлдэх байсан. Би пролетарийн хувьсгалчаараа, марксистаараа, диалектикч материалистараа, тийм учраас шашингүйн үзэлтнээрээ үхнэ. Хүн төрөлхтний коммунист ирээдүйд итгэх итгэл маань одоо залуу явсан үеийнхээс дутуугүй цогтой, гэхдээ илүү бат бэх байна.

Наташа сая цонх руу очиж, миний өрөөнд агаар илүү чөлөөтэй оруулах гэж арай томсгож нээлээ. Би ханан дор байгаа хурц ногоон зурвас зүлгийг, ханан дээгүүр цухуйх цэлмэг хөх тэнгэрийг, бас хаа сайгүй сацарсан нарны гэрлийг харж байна. Амьдрал ёстой сайхан юм. Хойч үеийнхэн маань амьдралыг бузар явдал, дарлал, хүчирхийллээс цэвэрлэж, амьдралаар бүрэн дүүрэн цэнгэцгээж явах болтугай.

1940 оны хоёрдугаар сарын 27. Койоакан Л. Троцкий

Герман Зөвлөлт рүү довтлох гэж байгаа тухай тагнуулын анхны мэдээ 1940 оны зургадугаар сараас эхлэн ирэх болжээ. Сталин тэдгээрийг үл тооно. Ямар нэгэн германуудын тухай яриа бол донгосолт, орос хэл мэддэг хэдэн мянган шүхэрчин бэлтгэж байгаа гэдэг бол солиотой хүний зохиол, германы цэргийн ангиуд Польшийн нутаг дээр шилжин байрлаж байгаа нь эзэлсэн оронд байх цэргийн хэвийн амьдрал, германы цэрэг зөвлөлтийн хил дээр бөөгнөрч байна гэдэг бол төөрөгдүүлэх мэдээлэл, Черчиллийг хуурч, түүний анхаарлыг Англид цөмрөн орох бэлтгэлээс хөндийрүүлж байгаа хэрэг.

Илүү ноцтой сэрэмжлүүлэг Германы жанжин штабт байгаа агентаас аравдугаар сард ирэв. Герман ЗСБНХУ-тай ирэх оны хавар дайн хийж эхэлнэ, зорилго нь Украиныг тасдаж авах. Энэ мэдээлэлд итгэж болохгүй, ирэх жилийн хавар гэхэд Гитлер Англитай хийж байгаа дайнаа дуусгаж амжихгүй, Ла Маншийн хоолойгоор өвөл гатлана гэж байхгүй.

Бас зөрүүд дүнхүү Литвинов Герман зайлшгүй довтлох тухай, Молотовын буруу бодлогын тухай бураад салахгүй байна, тэр Молотов гээд байгаа нь, мэдээж, Сталин л гэсэн үг.

“Франц бут ниргүүлсэн нь зөвлөлтийн бодлого бүрмөсөн дампуурсны илрэл. Одоо Гитлерт хоёрдугаар фронт байхгүй, Англи бол хоёрдугаар фронт биш. Одоо рейх бүх эх газрын Европын нөөц бололцоонд тулгуурлаж байна. Гитлерийг өөгшүүлэх бол толгойгоо элсэнд нуудаг тэмээн хяруулын бодлого”.

Юу ч ойлгодоггүй зөнөг годил! Гитлер Зөвлөлт Холбоот Улс руу довтлохгүй. Мэдээж тийм шалтаг өгөхгүй бол тэр шүү, Гитлерийн болчимгүй занг бодолцож байх ёстой. Гитлер түүний төвч байр сууринд итгэж байх ёстой. тэрээр Литвиновыг ТХ-ны жинхэнэ гишүүнээс орлогч гишүүн болгоно, тэгвэл Гитлер түүнийг еврей нараасаа салж байна гэж харна. Жемчужинаг бол ерөөсөө ТХ-ны бүрэлдэхүүнээс гаргана, Гитлер засгийн газрын удирдагч Молотовын эхнэрийг шохоорхог, түүнийг ч золиос болгож байгааг ч хараг.

Аравдугаар сарын 5-нд Улс төрийн товчоогоор улс орны батлан хамгаалах төлөвлөгөөг хэлэлцэв. Тимошенко, Шапошников, Жуков мөн Жанжин штабын нэг удирдагч, төлөвлөгөөг боловсруулсан Васильевский нарыг дуудсан аж. Васильевский илтгэв.

Васильевский санваартны гэр бүлээс гаралтай, эцэг нь одоо хүртэл бөглүү гацаанд өөрийн хуралтай. Берия эерэг тодорхойлолт өгсөн. Ховор тохиолдол. Дэлхийн нэгдүгээр дайнд штабс-капитан болтлоо алба хаасан, 1919 оны тавдугаар сараас Улаан Армид алба хааж байгаа, эхлээд “Выстрел” сургууль, дараа нь Жанжин штабын академи төгссөн, гучин долоон оноос Жанжин штабт буй. Юмаа мэддэг, зөөлхөн, эелдэг хүн. Жуков, мэдээж, дайчин байлдагч, муйхар цэрэг, дургүй хүргэнэ, тэгвэл Васильевскийд эгдүүцэх арга байхгүй, нэг удаа тэрээр түүнд: “Нөхөр Васильевский, та ёстой хорхойд хоргүй гэгч бололтой... Арай чанга бай” гэж хэлсэн. Сталин түүнийг дундуур нь оролгүй сонсож байгаад, зөвхөн бэхжүүлсэн районы тухай ярих үед нь,

– Та чинь юу вэ, ухралт төлөвлөж байгаа юм уу? гэж асуув.

– Үгүй ээ, нөхөр Сталин, хэрхэвч үгүй! Бид зөвхөн давшилт төлөвлөж байгаа, гэхдээ энэ бол хил дээр хамгаалах шугам байгуулахыг үгүйсгэхгүй.

Сталин зогтусаад түүн рүү эргэв.

– Тийм, үгүйсгэхгүй. Шинэ хил дээр! Одоо Зөвлөлт Холбоот Улс шинэ хилтэй! Чухам түүнийг л бэхжүүл. Гэтэл та хуучин хилийг бэхжүүлэхийг бас төлөвлөж байна. Тэгвэл хуучин хил байхгүй, хэзээ ч бий болохгүй. Тэр хилийг март.

– Гэхдээ тэр хил сайн зэвсэгтэй, сайн тоноглогдсон, нөхөр Сталин гэж Васильевский зүрхшээн өчив.

– Маш сайн байна. Тэр чинь та нарт бэлэн тоног болно. Тэрийгээ аваад шинэ хил рүүгээ авааччих. Газар доорхи бүх барилга байгууламжаа хамтралуудад өгчих, үр тарианы агуулах болгоод ашиглаг. Хамгаалалтын хуучин барилга байгууламжаа үлдээнэ гэдэг чинь цэргүүддээ: “Айх хэрэггүй, та нарт ухрах газар байгаа, та нарын ар талд хүчирхэг хамгаалалтын шугам байгаа” гэж хэлсэн үг болно. Энэ бол армид ухрах санаа сэтгэл соёолуулна гэсэн үг, түүнд давшихийг биш, ухрахыг заана гэсэн үг. Та үргэлжлүүл!

Васильевский үргэлжлүүлэв. Төлөвлөгөө нь ч буурьтай байж, Васильевский ч ойлгомжтой тайлбарлаж. түүнийг тайлбарлаж дуусахад өрөөнд нам гүм болов. Цэргийнхэн төлөвлөгөөгөөрөө бүх юмаа нэгэнт хэлчихсэн учраас дуугүй байна, Улс төрийн товчооны гишүүд, энэ талаар нөхөр Сталины юу бодож байгааг мэдэхгүй учраас бас дуугүй байна.

Сталин өрөөн дундуураа холхин ярьж эхлэв:

– Жанжин штабын чиглэл надад сайн ойлгогдохгүй байна...

тэрээр хэзээнийхээ янзаар, цаадуулыгаа үг болгоныг нь хүчлэн байж чагнахаар намуухан дуугаар, зугуухан, тов тод ярьж байна.

– Жанжин штабын зорилтын үндэс юу байна? Тэр нь манай гол хүчийг Баруун фронт дээр төвлөрүүлэхэд оршиж байна. Энэ зорилт юунаас үүдэж байна вэ? Энэ бол германууд дайн хийсэн нөхцөлд гол цохилтоо, мэдээж, хамгийн богино зам болох Брест — Москвагийн чиглэлээр хийх гэж оролдоно гэсэн таамгаас үүдэж байна. Тийм зорилттой санал нийлж болох уу? Тийм зорилттой санал нийлж болохгүй гэж бодож байна. Германууд энэ хамгийн богино замаар явахгүй гэж бодож байна. Тагнуулын бүх мэдээнээс үзвэл германууд Украиныг булааж авахыг хүсч байна. Тагнуулын энэ мэдээнд үг дуугүй итгэж болох уу? Мэдээж болохгүй. Тэдгээр мэдээнд төөрөгдүүлэх мэдээлэл, шал худлаа зүйл, тэнэг юм зөндөөн бий. Хэдий тийм боловч Украин байнга дурдагдаж байгаа нь санаандгүй хэрэг биш. Яагаад санаандгүй биш байх вэ? Гитлерийг Зөвлөлт Холбоот Улстай дайтаад эхлэх юм гэж санавал, энэ бол урт хугацааны дайн болно, ЗСБНХУ бол, Польш юм уу, Франц биш, бас талх тариагүй, түлш шатахуунгүй, түүхий эдгүй бол тийм дайн явахгүй. Тэгэхээр, германуудын хувьд Украины тариа, Донбассын нүүрс, Криворогийн хүдэр, Никополийн марганец онцгой ач холбогдолтой. Тийм учраас Гитлер гол цохилтоо баруун биш, баруун өмнөд чиглэлээр бэлтгэх болно. Нөгөөтэйгүүр, Гитлер Балканд нэгэнт бэхжээд авсан юм чинь, тэндээс цохилт

хийхэд түүнд амар байх болно. Ийм үндсийг удирдлага болгон төлөвлөгөөг боловсруулах хэрэгтэй.

тэрээр чимээгүй болзогноо,

– Та нарт татгалзах зүйл байна уу, нөхөд өө? гэж асуув.

Германы Жанжин штабын төлөвлөгөөгөөр тэдний гол хүч Смоленск, Москва хоёр руу чиглэсэн байгааг Тимошенко, Шапошников, Жуков, Васильевский дөрвийн хэн нь маш сайн мэдэж байв. Түүгээр ч барахгүй, Гитлер Европын орнуудыг сөхрүүлж авахдаа, дайныг аль болохоор түргэн дуусгахын тулд юуны өмнө нийслэл рүү нь зүтгэлж байсан. Энэ бол түүний сайтар боловсруулсан, шалгагдсан, зөв нь нотлогдсон тактик.

Гэвч тэдгээрийн хэнд ч Сталиныг сөрөх зүрх байсангүй.

– За тэгвэл татгалзах зүйлгүй юм байна. Жанжин штабыг дахин бодож, төлөвлөгөөг арав хоногийн дараа илтгэхийг хүсье хэмээн Сталин асуудлыг хаав.

Аравдугаар сарын 14-нд төлөвлөгөөг дахин Улстөрийн товчоонд илтгэв. Энэхүү дахин боловсруулсан төлөвлөгөөнд гол цохилтыг баруун өмнөд чиглэлээр ирнэ гэж үзэж, түүгээр зөвлөлтийн цэргийг хамгийн их төвлөрүүлэхээр товложээ.

Сэтгэл ханасан Сталин, хурлын дараа цуг үдийн хоол идэхээр бүгдийг нь доод давхарт, гэр рүүгээ урив.

Сталин нөхөр Васильевскийн эрүүл мэндийн төлөө хундага өргөж, дарснаасаа бага зэрэг балгаад, гэнэт,

– Нөхөр Васильевский, та шашны сургууль төгссөнийхөө дараа яагаад лам болоогүй юм? гэж асуув.

Сандарч мэгдсэн Васильевский өөрөө, бас гурван дүү нь амьдралын өөр зам сонгосон гэх маягийн юм бувтнав.

– За тийм байж, тэгэх хүсэл байсангүй, ойлгомжтой хэмээн Сталин инээмсэглэж, – Харин Микоян бид хоёр бол лам болох гэсэн, даанч бид хоёрыг, яагаад ч юм бэ, аваагүй юм гэснээ Микоян руу эргэж, – Юу билээ, Анастас, чамайг ламаар аваагүй бил үү? гэв.

– Аваагүй ээ, нөхөр Сталин хэмээн Микоян нотлов.

– За тэр дээ. Яагаад аваагүйг нь бид өнөөг хүртэл ойлгохгүй байгаа юм гээд Сталин гараа алдлав.

Жолоодогч нь тоглоом хийн наргиж, урамтай байгаад цөмөөрөө баярлан инээлдэцгээв.

Сталин чимээгүй азснаа дахиад Васильевский рүү харав.

– Нөхөр Васильевский, та нэг юм хэлвэл болох сон болов уу, та өөрөө ч, бас дүү нар чинь ч гэсэн эцэгтээ яагаад тусалдаггүй юм бэ? Миний л мэдэхээр бол нэг дүү чинь эмч, нөгөө нь агроном, бас нэг нь нисгэгч. Та нар бол бэлтэй хүмүүс. Та нар эцэг, эхдээ туслаж болох байсан гэж би бодох юм, тэгсэн бол өвгөн аль хэзээний тэр сүмээ хаях байсан байх. Тэр сүм нь яаж ийж амь зуухад нь л хэрэг болж байгаа шүү дээ.

Жолоодогч юу хэлэх гээд байгаа, энэ бүхэн Васильевскийн хувьд яаж эргэхийг мэдэхгүй учир одоо инээх хүн алга.

Васильевский сэтгэлээ барьж ядан байж,

– Ийм юм л даа, нөхөр Сталин, би бүр 1926 онд эцэг эхээсээ аливаа харилцаагаа тасалсан юм гэж тайлбарлав.

– Эцэг эхээсээ харилцаагаа тасалсаан? хэмээн Сталин үнэхээр гайхаж байгаа дүр исгэн асуув.
– Яагаад тэр билээ, хэрэв нууц биш бол?

– Тэгээгүй бол би манай намын эгнээнд байхгүй байх байсан, Жанжин штабын системд битгий хэл, Улаан армид ч алба хааж чадахгүй байх байсан.

– Манай нам, манай арми үнэхээр тийм журамтай гэж үү? хэмээн аанай л гайхсан янзтай асуув.

Нам, арми хоёр чухамхүү тийм журамтайг бүгдээрээ мэдэх боловч үүнийг нөхөр Сталинд хэн нь ч нотлон хэлсэнгүй. Нөхөр Сталин өөрөө үүнийг сайн мэдэж байгаа юм чинь.

Гэвч Васильевский өөрийнх нь хэлсэн үг зүй ёсных гэдгийг батлах ёстой, тэгэхгүй бол Сталины нүдэнд худалч хүн болж харагдана гэдгийг ойлгож байв. Тэгээд ингэж хэлэв:

– Нөхөр Сталин, таныг болгоовол, би танд нэг ийм явдлын тухай ярьж өгье...

– Тэг л дээ...

– Хоёр долоо хоногийн өмнө, энэ олон жилийн хугацаанд санамсаргүй, анх удаа эцгээсээ захиа авлаа. Би 1926 оноос хойш биеийн байцаал бөглөх болгондоо, миний эцэг санваартан, түүнтэй биеийн болон бичиг захидлын ямар ч харилцаа байхгүй гэж бичдэг юм. Тэгтэл гэнэт захиа ирлээ. Энэ захидлын тухай би тэр дор нь намын байгууллагынхаа даргад илтгэсэн. Тэгээд дарга маань надад, захидалд хариу өгөхгүй байх, цаашид ч эцэг эхтэйгээ хуучин янзаар харилцахгүй байх шаардлага тавьсан.

Сталин ширээний ард суугаа Улс төрийн товчооны гишүүдийг гайхан харав. Цаадуул нь өөрсдөөс нь юу шаардаад байгааг сая ойлгож, хариуд нь мөн гайхаж, тэр ч бүү хэл, дургүйцэж байгаагаа царайгаараа илэрхийлэв.

– Танай намын дарга тэнэг толгой, Жанжин штабт ажиллах эрх түүнд байхгүй, Жанжин штабт годилууд биш, ухаантай хүмүүс хэрэгтэй. Улаан Арми нийгмийн гарлаар хуваагдмал биш, нэгдмэл, цул байх ёстой. Лениний эцэг тайж хүн байсан, Ленин эцэг эхээсээ

татгалзаагүйг та нар мэднэ. Нөхөр Васильевский, би танаас, танай дүү нараас, эцэг эхтэйгээ нэн даруй харилцаа тогтоохыг, тэдэндээ тусламж байнга үзүүлж байхыг хүсч байна. Бас энэ тухай танай намын байгууллагын даргад уламжлаарай, мэдээж, тэр үед чинь тэр хүн намын дарга хэвээрээ байвал, тэр хүн Жанжин штабт ажиллаж байвал уламжлах хэрэг шүү дээ.

Мария Константиновна Москвагаас ирсэн бичгийг Глебт дамжуулав: Урлагийн хороо түүнд Залуу үзэгчдийн театрт зураачаар ажиллах боломжтой хотоо сонгохыг санал болгожээ. Нэр заасан хотуудынх нь дотор Калинин байж. Тэнд уран сайхны шинэ удирдагчтай болсон, хуучин нь байхгүй, Глеб түүнээс болж тэр театраас гарсан. Глеб Калининг сонгов.

Гэхдээ мань хүн яарахгүй байв. Ленагаас болж явахаа хойшлуулаад байгаа нь илэрхий. түүнд сэтгэл алдарчихаж. Охидтой уулзахаа больсон. Саша ч бас больсон, залхаж гүйцэж. Мөн навс уухаа больцгоосон.

Глеб нэг удаа Ордонд сүрхий догдолсон байдалтай хүрч ирэв.

– Миша Каневскийг баривчилчихаж. Бас өөр ч зарим хүнийг тэгсэн гэгцгээж байна. Уфаг цэвэрлэж байх нь. Саша,

– Хичээлийнхээ дараа Лена дээр очицгооё гэв.

– Шөнө очихоор чинь тэд нарыг сандраачихна. Гэгээтэй дээр одоо явах хэрэгтэй.

– Бидний оронд энэ бүлэгтэй хичээллэж байхгүй юү, чи хөгжмөө тоглоод, эд нар сургуулилж байг гэж Саша Стасикаас гуйв.

Нэг машин бариад, үйлдвэрийн тосгон хүрцгээв.

Пүнзэн байшингийн суурины манаасан дээр, нэг нь хөгшин, таяг тулчихсан, нөгөө хоёр нь арай залуу гурван авгай сууж байна.

– За эгч нар минь, нэг гуйлга байна хэмээн Глеб малилзав. – Елена Ивановна Будягинаг дуудаад өгөхгүй юү. Өөрсдөө орохоос айж байна.

– Юунаасаа айгаав? гэж нүд нь гялалзсан эмгэн асуув.

– Энэ чинь эмэгтэйчүүдийн байр, охидууд барьж аваад тавихгүй.

– Тэр ч магадгүй шүү гээд авгай инээв. – Ямар сайхан залуус вэ. Хааныхн багачуул болж байна?

– Нэг тосгоныхон, нэг пийшин дээр эсгий гутлаа хатаацгааж байсан улс.

– Яасан алиа сухай вэ, нэр чинь хэн юм, Ленад юу гэх юм? гэв.

– Тосгоныхон чинь иржээ, бэлэг сэлттэй ч яваа юм уу гэсхийгээд хэлчих.

Лена Хөдөлмөрийн ордонд очихдоо өмсөж явсан хээгүй дашинзтайгаа гарч ирээд, тэдэн рүү гайхсхийснээ, яагаад ч юм бэ, арагшаа хулмаганан харав.

– Хүүхдийн талбай руу очигцоо, тэнд вандан сандал байгаа гэж эмгэн хэлж өгсний дагуу тийшээ очигцоов.

– Бидний танил, Ленинградаас хөөгдсөн нэг төгөлдөр хуурчийг баривчилсан байна. Өөр ч бас зарим нэг хүнийг авч явсан гэлцэж байна. Цөлөгдсөн хүмүүсийг эндээс түүж байх нь. Чамайг ч шүргэж мэдэх юм гэж Саша ярив.

Лена чимээгүй сонсож байснаа, хараагаа дээшлүүлэв.

– Манай үйлдвэр дээр тайван байгаа.

– Тэр ч цаг хугацааны л асуудал.

– Мэдээж, гэхдээ үйлдвэрийг барьж дуусахаас нааш хэнд ч, ялангуяа жирийн ажилчдад гар хүрэхгүй гэж бодож байна, ажилчид одоо их дутагдаж байгаа.

– Хэзээ барьж дуусах юм?

– Сарын сүүл рүү.

– Чи тэгээд баривчлахыг нь хүртэл хүлээх санаатай юм уу?

– Би яахсан билээ?

– Яваад өгөхгүй юү.

– Хаашаа?

Глеб сандал дээрээс босов.

– Лена, цаг алдахаа больцгооё. Калинин явцгаая. Нэн даруй. Миний гэр, ажил тэнд байгаа, өөрийн хүмүүс ч бий. Хоёулаа бүртгүүлээд, та миний овгийг авчих, хүү чинь бидэнтэй цуг байна, тэр чинь бас миний хүү болно.

Лена түүн рүү духайсхийн харав.

– Хонгорхон Глеб минь, танд баярлалаа. Би тантай аз жаргалтай байх байснаа би мэдэж байна. Гэвч тэд нар намайг тэртэй тэргүй олно, тэгсэн цагт та бас зовох болно. Би таныг зовоосой гэж хүсэхгүй байна.

– Таныг хэн ч, хэзээ ч олохгүй, би таныг хамгаалж чадна гэж Глеб зөрөв.

– Миний хэрэг мандаж эхэлхэд манай хөрш надад яваад өг гэж зөвлөсөн боловч би үгэнд нь ороогүй юм. Тэгээд буруудсан, одоо чи тэр алдааг хийж байна гэж Саша ятгав.

Цаадах нь толгой сэгсрэв.

– Тэгэхэд чи хүссэн зүгтээ яваад өгч болох чөлөөт хүн байсан. Харин би бол Уфагаас явснаараа оргосон болно, бүх холбоотын эрэл зарлаж олоод, зөвхөн “гэр бүлийн гишүүн” гэдгээр төдийгүй нэмэлт зүйл ангиар шүүнэ. Глеб минь, чи бид хоёр энэнээс эрт уулзаагүй нь харамсалтай, би элдвийг бодолгүй таны саналыг шууд хүлээж авах байсан гэснээ, түүн рүү энхрий харцаар хараад, – Глеб, угтаа бол та надад хайрын сэтгэлээ санал болгож байна, тийм биз дээ? гэв.

– Тийм, гэхдээ би бас танд дээр нь эрх чөлөөг санал болгож байна.

– Надтай бол та өөрөө тэр эрх чөлөөгөө алдана. Аль ч хоромд өөрийг чинь, бас дотны хүнийг чинь баривчилж мэднэ гэсэн бодолтой амьдрах бол аймшигтай гээд Глебийн мөрөн дээр гараа тавьж, – Глеб, та бол миний дотны хүн... Танд үнэнээ хэлэхэд, над шиг хүнд энэ пүнзэн байр, үйлдвэрийн харласан барилга энэ тэрээс хорихын байр ялгарах юм байхгүй. Хориход, тэр ч бүү хэл, арай тайван гэж би бодож байна гэв.

– Тэгвэл хориход чамд илүү тайван байх хэрэг үү?

тэрээр Сашагийн дуунд эвгүй аяс байхыг мэдээд түүн рүү анхааралтай харав.

– Тийм, би тэгж бодож байна.

– Тэгвэл хэний өмнөөс тайван байх болж байна? Хүүгийнхээ өмнөөс тайван байх юм болов уу? Чамд түүнээс үнсэлт дамжуулаад л, чамаас түүнд шоколад хүргэж өгөөд л?

– Саша, чи надтай яасан хатуу ярьж байх юм бэ?

– Таныг ийм байхад би өөрөөр яаж ярих вэ дээ. Төрсөн эцэг эхийн чинь туршлага таныг үнэхээр юунд ч сургасангүй гэж үү? Толгойгоо тавьж өгч, өөрснийгөө залгиулсан. Эрэн сурвалжлахаас л айж байна! Ямар шүүх чамайг шүүсэн юм? Ямар ч шүүх шүүгээгүй! Чамд хэдэн жилийн ял өгсөн юм? Хэдэн ч жилийнхийг өгөөгүй. Нэг хот руу явахыг х у у л ь б у с а а р тушаасан. Тэгээд та нар үг дуугүй захирагдаж, энд хорих ангийг хүлээхийн тулд яваад өгсөн. Чи чинь цэвэр паспорттой шүү дээ. Гурав хоногийн дараа Глебтэй бүртгүүлчихнэ, чамд өөр овогтой шинэ паспорт өгнө. Тэгээд хэн ч чамайг олохгүй. Гэтэл чи айгаад, хулчийгаад байна! Боол болж амьдраад сурчихсан, боол чигээрээ үхнэ дээ. Тэгж байвал таарна!

Лена газар шагайн зөндөөн удаан дуугүй байснаа Глебээс,

– Глеб, та байрны чигт харж байна. Тэнд хэдэн эмэгтэй байна? гэж асуув.

– Дөрөв.

– Та нарыг ирэхэд гурав байсан уу?

– Тэгсэн.

– Дөрөв дэх нь ногоон ноосон цамцтай байна уу?

– Тийм байна.

– Биднийг ажиглагчдын нэг нь. Тийм учраас би байр хүртэл дөхүүлж өгөхийг зөвшөөрөхгүй байсан юм. Хэрэв би одоо та нартай явчихаад, эргэж ирж хонохгүй бол, эсвэл бүр өглөө ажилдаа гарахгүй бол намайг хайгаад бөөн юм болно. Бид одоо шууд яваад өгч чадах уу? Галт тэрэг байна уу?

– Ленинградын суудал өдөр, арван хоёрт явдаг юм.

– За тэр дээ! Би зөвхөн амралтын өдөр л явж чадна.

– Тэр чинь хэзээ юм?

– Нөгөөдөр.

– Хүлээх осолтой, заавал галт тэргээр явах албагүй, усан онгоцоор явж болно, дараа нь нэг газар өөр унаанд шилжээд суучихгүй юү гэж Глеб өгүүлэв.

– Хонгорхон Глеб минь, тэдний хүмүүс чинь галт тэрэгний буудал, усан зогсоол, тэр ч байтугай автобусны буудал гээд хаа сайгүй байгаа. Манайхнаас ганц нэг хүн явах гэж оролдоод баригдсан. Энд аль болохоор хожуу мэдэх нь чухал, тийм учраас амралтын өдөр оргох хэрэгтэй. “Оргох” гэж ямар үг вэ дээ... гээд Лена мушилзав.

– Надад бол таалагддаг үг гэж Глеб тоглоом болгох гэж үзэв.

Саша бослоо.

– Нөгөөдөр өглөө бид чамайг гэртээ хүлээж байя. Эртхэн ирэхийг хичээгээрэй, өөр ч хувилбар гарч ирж магадгүй.

– Би яг есд очно. Юм хумгүй очно гэдгийг та нар ойлгож байгаа гээд инээмсэглэв. Яг хуучных нь ичингүйрсэн инээмсэглэл мөн дөө. – Глеб, та л намайг шинэ өмсгөлтэй болгох ёстой болно доо.

Глеб маргааш нь ажлаас халагдах юмаа цэгцлэв. Семён Григорьевич баахан ярвайсан боловч хүн шинэ ажлынхаа газар руу явах гэж байгаа юм чинь яалт ч үгүй болжээ. Глеб түүнд гурав хоногийн дараа явна гэж хэлээд, өөрөө Ленинградын маргаашийн суудалд тасалбаруудаа авчээ. Тэндхийн танилууд нь бүгдийг жин тан болгож өгсөн аж.

Глеб орой гэртээ юм хумаа эмхэлж байхдаа Сашад,

– Алга гэж мэдэхэд нь тэр аль хэзээний Калининд байж байна, учрыг нь олох гэж байх хооронд нэгэнт Елена Ивановна Дубинина болчихно. Энэ нэр аятайхан сонсдож байна уу? гэв.

– Сонсголонтой байна.

– Бүх холбоотын эрэл зарлах уу? Энэ бол цагдаа, хотод суух зөвшөөрөл, боловсон хүчний хэлтэс энэ тэрд хамаатай. Иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх газраар шагайхгүй. Нэмэрт нь түүний хуучин паспортыг дээгүүр нь сараачаад надад өгчихнө, танил охид байгаа, би тэрийг нь шатаачихна. Хүүг нь өөрсөд дээрээ авна, тэгж байтал нэг мэдсэн чинь өөрсдийнхийгөө бүтээчихнэ.

– Нэг их ухаан зарах ажил биш.

Глеб эцэст нь чемоданаа хааж, дээр нь баян хуураа тавиад ширээ рүү суув.

– За, үдэлтийн ганц ганц хундага татацгаах уу?

– Ленагийн дэргэд чи энэ тухайд арга буюу хумигдана шүү, нөхөр минь.

– Бүү санаа зов. Бүгд ухаалаг хязгаарын дотор байх болно. Би чинь одоо хариугүй гуч хүрлээ шүү дээ, ялдам минь. Чиний Пушкин чинь гэрлэх тухайд юу гэсэн билээ?

– “Хорин насандаа дэгжин эсвэл хийморьтой явагч, харин гучин насандаа хожоотой гэрлэгч”.

– Алив, энэний чинь төлөө татчихъя.

Хоёулаа татчихав. Глеб лонхыг бөглөж шүүгээ рүү хийв.

– Болоо! Чамд үлдээлээ.

Дахиад ширээ рүү суув.

– Илүү олон юм ярихыг хүсэхгүй байна, ялдам минь.

– Чиний үг цөөтэйг би мэднэ гээд Саша инээд алдав.

– Чухмаа чухам. Гэхдээ би чамд ийм юм хэлнэ. түүнийг шуудан дээр хармагц энэ бол миний хувь тавилан гэж шууд ойлгосон. Юмны учир, ялдам минь, түүний хөөрхөн, олон хэл мэддэг энэ тэрд нь байгаа юм биш, шал өөр юманд байгаа...

мань хүн чимээгүй болзогноо үргэлжлүүлэв:

– Тэр чинь чамтай нэг үүлдрийнх шүү дээ, эелдэг зантай. Гэхдээ түүний энэ чанар нь надад бол энхрийлэх, сүслэх сэрэл төрүүлж байгаа юм, ийм эрхэмсэг үг хэлж байгааг минь уучлаарай. Чи эр хүн юм бол энэ хорвоод үхлүүт барьцтай бух нохой байх ёстой. Харин тэр бол хүүхэн, бух нохой байж чадахгүй. За тэр чиний Ульяна бол...

– Чи түүнийгээ ав л даа.

– Хэнийх гэдэг нь чухал биш. Ульяна бол бух нохой. Харин Лена бол хүүхэн, би түүнийг хамгаалж, энэ булай хорвоогоос сэргийлж байхыг хүсч байна. Би түүнийг дэр мод чирдэг гэж дуулаад, тийшээ очиж тэр муусайн захирал, аравны дарга энэ тэрийг нь хэмх балбамаар

санагдсан, би бүр тийм хачин болчихсон. Нэг юмыг өөртөө уучилж чадахгүй байна: хоёр долоо хоногийн өмнө, Москвагаас бичиг ирэнгүүт яагаад түүнийг шууд аваад явчихсангүй вэ. Хулчийсан юм, ялдам минь. Тийм хүүхэн! Яасхийж эвийг нь олох вэ? Яаж хэлэх вэ? Яаж санал тавих вэ? Тэгээд Каневскийн тухай мэдэнгүүт: аминд нь орох хэрэгтэй, ямар ч байсан аврах хэрэгтэй гэж шууд шийдсэн. Хайртай, хайргүй нь огт хамаагүй, гол нь түүнийг эндээс авч явах... Гэтэл одоо сонсоо биз? “Та бол миний дотно хүн”. Ямар вэ дээ?! “Би тантай аз жаргалтай байх байсан”. Ямар вэ, ялдам аа?! Чамд хэн нэгэн ийм үг хэлж байсан уу? Надад бол хэзээ ч үгүй!

– Лена гайхамшигтай хүүхэн, би түүнийг олон жил мэднэ. Би та хоёрын өмнөөс баяртай байна. Харин одоо унтацгаая. Чи бид хоёр чинь үд болтол хурхираад сурчихсан улс, маргааш эрт босох ёстой...

Тэр хоёр есөн цагт яг бэлэн байсан боловч Лена хараахан ирээгүй байв. Глеб өрөөн дотуур хий холхин, ирж явна уу, үгүй юү гэж байн байн цонх руу очно.

– Ямар нэг саад гараа биз, ингээд ирнэ гэж Саша түүнийг тайвшруулна.

Цаг арав боллоо, дараа нь арван нэг... Галт тэрэг цагийн дараа...

– Галт тэрэгний буудал руу шууд очсон юм болов уу? гэж Глеб дэмий таамаг тавив.

– Юу гэж тийм тэнэг юм хийх вэ, амралтын өдрийг нь л хойшлуулсан болж таарах нь.

Арван хоёр цагт тэр хоёр Ленагийнх руу явцгаалаа.

Байрны манаасан дээр түрүүчийн удаа ярилцсан, нөгөө таягт авгай сууж байв. Саша, Глеб хоёрыг хараад,

– Явцгаа, багачуул минь, явцгаа, Лена байхгүй гэж аяархан хэлэв.

– түүнийг хэзээ аваад явчихаав?

– Өчигдөр, явцгаа, явцгаа.

Тэр хоёр хөдөлсөнгүй.

Эмгэн Глебийг хуруугаараа дохин дуудав.

– Тэр чинь ямар ястан юм бэ, хүү минь?

– Орос шүү дээ.

– Тэгвэл ямар сүсэгтэй юм бол? Үнэн алдарт уу, эсвэл өөр аль нэг үү?

– Үнэн алдарт.

– Бурхан өршөөх болтугай хэмээн эмгэн шивнэв.

Егор Сазановын гудамжин дахь ДЯАК-ын байрны үүдний танхимд тэд биеийн байцаалын хуудас бөглөв: Будягина Елена Ивановна, 1911 онд төрсөн, хаяг — Нефтегаз тосгон, асууж байгаа хүн — Дубинин Глеб Васильевич, төрөл садны ямар холбоотой...

– Сүйт хар хүү гээд биччих гэж Саша зөвлөв.

– Үгүй ээ, бөл ах гээд бичихье, тэр нь дээр.

– Будягинтай төрөл болох гэж бүү зүтгэ, ойлгов уу? Сүйт хар хүү гэж бич!

– Хэн ч өөрийгөө сүйт хархүү гээд хэлчихэж болно, нохой гахайн чинээ ч тоохгүй. Харин хамаатанд нь бол? Магадлагаа өгөхгүй байх гээд үзэг л дээ!

– Битгий амьтан үргээчих. Журам эвдэхийн хэрэггүй!

– Мэдэж байна, ялдам минь! Гол нь чи битгий хоншоороо дүрээд бай, хамаг хөгжмийн хөг алдуулахаас цаашгүй.

Глеб цонх руу очиж тогшоод, бөглөсөн хуудсаа өгөв.

– Хүлээгээд байж бай!

Хэдийгээр тэнд цөөхөн хүн байсан ч тэр хоёр бишгүй удаан хүлээлээ. Тамхиа ээлжээр гарч татацгаав. Глеб бичгээ өгсөн цонх руу тэсч ядан хялалзаж, нааш цааш холхино.

– Дубинин!

Глебийг цонх руу очиход, Саша хажууд нь очиж зогсов.

– Паспорт оо!

Саша гараас нь барьж авав — битгий өг!

– Та миний паспортоор яах гэв?

– Магадлагааг эзнийг нь нотолсон баримт бичгээр өгдөг юм.

Глеб Сашаг цааш нь түлхээд, паспортоо гаргаж өгөв.

Цонх хаагдлаа.

Тэр хоёр холдосхийн зогсов.

– Чи эд нарт яах гэж паспортоо өгч байгаа юм?! Надад одоо алга гээд л хэлчихгүй. Одоо Уфад Будягины хамаатныг оллоо гээд сүйд болно. Оройтоогүй дээрээ эндээс зайлъя! Калининд

очоод шинэ паспорт олно биз гээд Саша Глебийг үүд рүү чангаасан боловч цаадах нь дахиад түүнийг түлхчихэв.

– Ленаг хаана байгааг мэдэхээс нааш би эндээс явахгүй.

түүний бодлыг өөрчлөх арга алга. Хэзээний болгоомжтой хүн чинь одоо дөргүй юм шиг зүтгэж байна.

Цонхны дэргэдэх хаалга нээгдэж, нүдний шилтэй, бүдүүн бахим офицер үзэгдэв. тэрээр цаасаа ойртуулж хараад,

– Дубинин! гэв.

– Би Дубинин байна.

Офицер түүн рүү анхааралтай харснаа, хаалгаа томсгон онгойлгоод,

– Ийшээ оръё! гэв.

– Яах гэж?

– Яахыг танд тэнд хэлж өгнө, орцгооё!

– Яагаад энд биш, тэнд гэж байгаа юм?

– Та Елена Ивановна Будягинагийн тухай магадлагаа хүсч байгаа юу?

– Тийм, би.

– Тэгвэл тэр магадлагааг чинь тэнд л танд өгнө шүү дээ.

Саша тэдэн рүү очив.

– Глеб, ажлаасаа хоцрох нь.

Офицер түүн рүү бүлтийн харав.

– Та юун хүн бэ?

– Нөхөр нь. Ажил руугаа явж байсан чинь ийшээ цуг оръё гэхээр нь орж ирээд байна.

– Тэгвэл та яв. Нөхөр чинь таныг гүйцээд очно. Иргэн Дубинин, орцгооё.

– Глеб! хэмээн Саша түүний ханцуйнаас угзрав.

Офицер түүний мөр рүү бүдүүлгээр түлхчихээд, Глебийн араас орж, хаалгаа тасхийтэл хаалаа.

Саша үзэн ядах, цөхрөх хослон, хүчин мөхөс байгаадаа гутран бахардав. Хашгачиж эсэргүүцэх үү? Хэдэн дөрвөлжин нүүртэй мангар юм гарч ирээд, гарыг нь мушгиж балбачихаад, шоронгийн өрөө рүү хийчихнэ, тэндээс гарах зам тодорхойгүй. Улс орны эрх мэдлийг эрүүгийн бүлэг булаагаад авчихсан, түүнтэй яаж тэмцэх вэ?! Гарцаагүй үхэл рүү явах уу? түүний үхэл хэнд ч, ямар ч тус хүргэхгүй, тэр ч бүү хэл, түүний тухай хэн ч олж мэдэхгүй.

Саша гадагш гарч, нэг машин зогсоогоод, Семён Григорьевичийн хаягийг хэлэв. Глеб тэр хоёр эртний харилцаатай, нэмэрт нь Семён ДЯАК-ын клубт хичээл зааж байсан, ямар нэг хэлхээ холбоо гарцаагүй үүссэн байж таарна, хэрэгтэй товчийг нь олж дараад, Глебийг аврах ч юм бил үү?

Семён Григорьевич Сашагийн ярьсныг сонсоод, ямар нэг юм мэдэж өгөхөөр амлав. Юу ч мэдэж чадсангүй гэж өдрийн сүүл рүү мэдэгдээд, Сашагаас хараагаа дайжуулан, жүжигчний сайхан дуугаараа ийн нэмж хэлэв:

– Сашенька, таны хоёр бүлгийг би өөрөө дуусгая, та ажилласан цагийнхаа тооцоог Ноннагаар өнөөдөр бодуулж болно.

За тэр. Өөрөөс нь ангижирч байна. Глебт бас тус болохгүй нь.

– За тийм байж, тооцоогоо бодуулж болж байна. Гэхдээ тэгээд гүйцэхгүй шүү, Семён Григорьевич, танайд тэднээс тэдэнд ажилласан гэсэн магадлагаа надад хийж өгөх хэрэгтэй, чөлөөлөгдсөн тухай паспортонд тэмдэг дарах хэрэгтэй гэж Саша өгүүлэв. Тэгээд халааснаасаа бичиг баримтаа гаргаж дундаас нь үйлдвэрчний батлахаа олж нээв. – Тэгнэ ээ тэр, сүүлийн гурван сарын татвар төлөөгүй байна. Би ч ийм л хариуцлагагүй өртөн дөө.

– Саша... Гэхдээ та ойлгож байна уу?! Та энд саатах хэрэгтэй болно.

Саша дал мөрөө хавчив.

– Надад яарах юм огт алга. Өөр ажил ч олж магадгүй.

Семён Григорьевичийн нүд нь бүлтийгээд ирлээ.

– Би таныг арай хэрсүү гэж бодож байсан юм. Таны хамгийн дотны нөхрийг чинь барьчихлаа. Таны надад санал болгож байсан хүүхэн бас баригдсан.

– А-яа-яа, Семён Григорьевич, та өөрийнхөө энд ямар гээчийн үүр барьсан юм бэ хэмээн Саша инээд алдав.

тэрээр түүний айсан царайг харж бахаа хангав. Сашаг нүд ирмэхийн зуур алга болгох санаатай гэнэ. Үгүй шүү, тэгж амархан алга болохгүй! Зугтахгүй, зайлахгүй! Хүссэн цагтаа л явна. Шоронд хийх үү? Хийцгээ л дээ. Ямар ч байсан өөрөө ухаан жолоогүй зугтах бодолгүй байна. Хүчин мөхөс нь үнэн, Лена, Глеб хоёрын төлөө мань хүн юу ч хийж чадахгүй байна, гэхдээ тэр хоёрыг зүгээр тэгээд орхичихгүй.

– Болгоож үзээрэй... хэмээн Семён Григорьевичийн дуу сөргөлдөх аястай болоод ирлээ. – Тэр хүүхний чинь би барааг нь ч хараагүй, овгийг нь сонсонгуутаа ажилд авахаас шууд татгалзсан.

– Наадахыгаа өөрийнхөө гавьяа гэж үзэж байна уу? За яахав, энэ сэдвээр ёс суртахууны мэтгэлцээн хийхээ больё. Та намайг явуулахыг хүсч байгаа чинь тодорхой байна. Мария Константиновна ийм тушаал буулгаа юу?

– Тийм, Мария Константиновна ч таны хувьд яваад өгөх нь хамгийн зөв гэж үзэж байгаа.

– Таныг яв гэж зөвлөхгүй байна уу?

– Бид дахиад хоёр бүлгийг төгсгөх ёстой.

– Тийм байх... “Хоёр бүлэг”. Та тэднийг төгсгөхгүй дээ, Семён Григорьевич. Та нүглээс зугтаад арилж өгнө. Араасаа нэхэл дагал болгохгүйн тулд, элдэв гомдол санал гаргуулахгүйн тулд дутуу үлдсэн цагийнхаа мөнгийг буцааж өгнө дөө. Бас бүх бичиг баримтаа ёсоор нь бүрдүүлнэ дээ. Би ч бас тийм л юм шаардаж байна. Миний баримт бичиг ч ёсоороо байх ёстой. Мария Константиновнад үүнийг уламжилж өгөөрэй.

Мария Константиновна Саша руу эвгүй хараад, паспортонд нь тэмдэг дарж, үйлдвэрчний батлах дээр нь татвар төлсний марк нааж, Аялан тоглох товчоонд ажилласан тухай магадлагаа хийж өгөв. Тэгээд, одоо гүйцсэн, энд суугаад байхын хэрэггүй, явж үз гэх маягтай утсаа барьж авав. Үл тоомсорлосон, муухай хандлага.

Саша паспорт, үйлдвэрчний батлах энэ тэрээ авч, яаралгүй халааслаад,

– Баярлалаа. Би Москвад очиж таарах байх. Ульяна Захаровнад юу уламжил гэж тушаах сан бол? гэв.

– Ульяна Захаровнад аа? Та чинь түүнтэй танил юм уу? хэмээн хүүхэн шижээргүй харав.

Мөн яатуу яа!

– Мартчихаа юу? хэмээн Саша гайхсан царайлав. – Би ч бас бага зэрэг мартагнасан байна. Би чинь нэг тохилог өрөөнд хэнтэй мөөгөөр даруулан архи ууж, толины доорхи орон дээр хэнтэй хэвтэж байлаа? Чи сануулах юм биш биз?

Ширээнийхээ ард тонгойн суугаа хүүхний буриад царайд шанаа нь тодроод ирэх шиг ч.

– Дуугай байна уу? Яагаад цагдаа дуудахгүй байна? Яагаад авраарай, туслаарай гэж хашгачихгүй байна? Манай өрөөнд танхайрч байна гэж!.. Айж байна уу? Мөөг, ор энэ тэрийн тухай намайг ярина гэж айж байна уу? Айх хэрэггүй, би ярихгүй. Чамаар нэрээ баастахыг хүсэхгүй байна!

Глеб маргааш нь ирсэнгүй, долоо хоногийн дараа ч ирсэнгүй. Юм хумыг нь авах гэж ч хүн ирсэнгүй. Зулбасаганууд, хүний шаарнууд! Саша ийм үзэн ядах сэтгэлд хэзээ ч автаж

байгаагүй, ингэж өс авахын түүс хэзээ ч болж байгаагүй. Өр төлөөсний цаг иртэл амьд явах юм сан.

тэрээр гэрийн эзэгтэйтэй тооцоо хийж, Глебийн чемоданыг эмхлэв. Глеб ирэхгүй хоёр сар болчихвол чемоданыг нь эгч авгайд нь явуулах ам өчиг баян хуурч Лёнягаас авав.

Шуудан дээрээс ээж рүүгээ утасдав. Хуучин янзаар тайван, хөгжүүн ярив. Уфагаас явж байгаа тухайгаа ганц үг ч цухуйлгасангүй. Ярианыхаа төгсгөлд цухас мэт боловч сайн ойлгогдохоор,

– Бидэнтэй сургуульд цуг байсан Лена энд байсан гэж хэлэв.

– Тийм, тийм, би мэднэ.

– түүний бие муудсан, удаан хугацаагаар... Хамаатан саднаас нь мэдэх хүндээ дуулгаарай. Чи ойлгов уу?

– Ойлголоо, ойлголоо, би дуулгана.

Ээж нь, мэдээж, Варяг хэлж байгаа. түүнд л дуулгана.

Максимумыг Москва руу шилжүүлсэнд Нина сэтгэл хангалуун байв. Орлого талаасаа арай дордох ч арай тайван болно. Москвад ч шоронд хийж байгаа, гэхдээ Максим Москвад тэгтлээ анзаарагдахгүй. Харин энд бол бүх юм нэг дор, хашаагаар хүрээлэгдсэн цэргийн хотхон, шахцалдуулан барьсан хоёр давхар, дөрвөн давхар байшингууд, бахь байдаг хэдэн хүний царай, нөгөө л болгоомжилсон харц. Максим Зөвлөлт Холбоот Улсын баатар, гэтэл чухам тэр баатар гэдэг нь, хэдийн хорооны захирагч болчихсон нь атаархал төрүүлнэ. Нина, Максим хоёр ийм занд дургүй, тэд хэзээнээс нааш ухаан, авьяасны давамгайллыг хүлээн зөвшөөрч ирсэн. Одоо бол хоёр санаалах, худал ярих, хов хүргэх энэ тэр л зан суртахууны хэм хэмжээ болжээ. Дарга нарын авгай хүүхнүүд өдөр нь болохоор нөхрийгөө албанаасаа эргэж ирэх эсэхийг мэдэхгүй, эр нөхрөө гэртээ ирсэн хойно, нь болохоор түүнийг шөнө нь барихаар ирэх эсэхийг мэдэхгүй. Нина нийтийн адил баривчилгааны талаар ярихаас айна, гэхдээ шөнө нөхрийг нь бариад явчихсан хөрш хүүхэндээ сэтгэл засах хоёр үг яаж хэлэхгүй байх билээ, шатан дээр таараад буруу харчих болж байна уу?

Нисэх хүчний командлагч Флеровскийг баривчилсан, Номхон далайн флотын командлагч Викторовыг бүх штабтай нь баривчилсан, Приморскийн цэргийн бүлэглэлийн командлагч Федько, дараа нь оронд нь томилогдсон Левандовский нарыг буудан цаазалсан...

Маршал Блюхерийн тухай шивнэлдэнэ. Москвад дуудан авчирч, Улс төрийн товчоон дээр шүүмжилсэн гэх. Гэхдээ Сталин түүнтэй эв найртай харилцаж, шинэ стратегийн төмөр зам барих асуудлаар түүнтэй зөвлөлдөж байсан бол Ворошилов түүнд Сочийн зусланд гэр бүлээрээ очиж амрахыг санал болгож. Тэгсэн чинь түүнийг чухам тэр зуслан дээрээс баривчилж, Москвад авчраад, дөрвөн мөрдөгч эрүүдэн байцааж, өрөөсөн нүдийг нь бүлт цохьжээ... “Адраад байвал үлдсэнийг чинь бүлт цохино шүү...” Берия дээр авчирсан чинь мань хүн түүнийг буудчихжээ. Авгайд нь найман жилийн хорих ял зааж, хэдэн хүүхдийг нь хүүхэд хуваарилах газраар тарааж, найман настай хамгийн бага нь ор сураггүй алга болжээ.

Энэ бүхэн үнэн эсэхийг Нина мэдэхгүй, ямар ч байсан тэгж ярьцгааж байж. Максимаас асуусан чинь,

– Энэ мэт яриаг битгий сонсож бай! гэж.

– Би сонсохгүй байлаа гээд юу өөрчлөгдөх юм бэ?! гэж Нина дүрсхийгээд, өрөөнөөсөө гарчээ.

Дараа нь тунгааж бодоод, тэгж уурласандаа харамсав. Максимумын хамаг мэдрэл байдгаараа хөвчирчихсэн байгаа, түүнийг улс төрийн хэлтэс, намын байгууллага, онцгой хэлтэс энэ тэр маш сэрэмжтэй мөшгин ажиглана, харьяа хүн болгоныхоо өмнөөс, тэдний хэлсэн үг болгоны төлөө хариуцлага хүлээнэ. Тийм учраас саяны асуултанд нь тэгж ширүүн хариулж л дээ, түүнд энэ тухай ярихад яаж амар байх вэ. Дуугүй л өнгөрөх ёстой байж, одоо тэвчих хэрэгтэй, энэ хотхонд хэдхэн сар байх үлдлээ, есдүгээр сард дамжааны хичээл эхэлнэ, Максим нэгэнт томилолт авчихсан байгаа.

Тэгээд хаалга онгойлгон, юу ч болоогүй юм шиг, Максимумыг дуудав.

– Нааш ир, Ваняд “Сайхан нойрсоорой” гэж хэл. Чамайг хүлээж байна.

Зөвлөлт засаг, нам хоёр бол Нинагийн хувьд одоо хэрнээ эрхэм ариун ойлголт хэвээрээ байгаа хэдий ч нөгөө нам, нөгөө зөвлөлт засаг нэгэнт байхгүй болсныг хичнээн харамсавч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болж. Москвад түүний намынх нь хуучин явдлыг ухаж төнхөөд мэдчихвэл базаахгүй юм болох нь мэдээж, гэвч дүүргийн намын хороонд түүний хэргийг хариуцаж байсан хүмүүсээс одоо хэн нэгэн үлдсэн нь юу л бол. Түүнчлэн ДЯАК-д ч хүмүүс нь бас солигдсон гэгцгээх юм. Арбатын байшингийнхнаас хэн ч юу ч мэдэхгүй, ер нь ч тэд нар тэнд суух гээгүй, цэргийн академийн дотуур байранд суух юм чинь.

Варя нөхрийнхөө гэрт амьдрах болсон ч Арбат дахь өрөөгөө хэвээр нь үлдээсэн, өөрийгөө төдийгүй Нинаг ч бүртгэлээс хасуулаагүй болохоор түүнд түлхүүрээ шууд өгөв. Нина байн байн тийшээ ирнэ, заримдаа хононо, тэгж байгаад ерөөсөө нүүж иржээ. Дотуур байрны өрөө нь жижигхэн учраас Максимын хичээлд Ваня саад болно. Тэгээд ч Максимын ээж зэргэлдээх орцонд нь байдаг болохоор Арбатад байх нь илүү эвтэйхэн, Нина ажил явдлаар гарах буюу Максим дээр очих хэрэг гарвал Ваняг эмээ дээр нь үлдээчихнэ.

Тэр байшингийнхан Нинагийн алга болсныг анзаараагүй шигээ ирснийг нь ч бас анзаарсангүй. Максим л сэтгэгдэл төрүүлж. Энд цахилгаан шатны жижүүр авгайн хүү гэж нэг бандь гүйж харайж байсныг хэн хүнгүй мэднэ, тэгсэн чинь Зөвлөлтийн баатар болчихсон байдаг. Максим дээр Нина тэр хоёрын сурч байсан сургуулиас төлөөлөгч ирж, сургууль өөрөөр нь бахархдаг, гэрэл зураг нь Лениний буланд байгаа гэж мэдэгдээд, хүүхдүүдтэй уулзалт хийж, өөрийнхөө гавьяаны тухай, Улаан Армийн баатарлаг үйлсийн тухай, японы самурай нарыг бут ниргэсэн тухай ярьж өгөөч гэж хүссэн ажээ.

Нина нэг удаа байрныхаа тэнд Юра Шарокийн ээжтэй тааралджээ. Цаадах нь түүнийг таньсангүй, эсвэл таниагүй дүр эсгэж. Нинатай хамт хүүгийх нь хүү, өөрийнх нь ач хүү явж байгааг яахин мэдэх билээ. Түүнтэй ярих хүсэл байгаагүй нь л яамай.

Нина Сашагийн ээж Софья Александровна руу утасдаж, ороод гарах зөвшөөрөл хүсэв. Гэнэтхэн гадаа тааралдчих вий гэж л их айж байсан, тэгэх юм бол хүн амьтны нүүрэн дээр юу ч ярьж чадахгүй, яриа нь ч яриа биш болж, Софья Александровнагийн нүдэнд тэрээр Сашагаас уравсан хүн болж хоцроно. Нина Сашагаас урваагүй, түүнд тэрслээгүй, харин ч түүнийг өмгөөлж бичиг хийж, гарын үсэг цуглуулж явсан, тэрнээсээ болж буруутсан учраас Москвагаас яваад өгсөн энэ тэрийгээ Софья Александровнад ярих санаатай байж. Хүнийсэх болсны шалтгаан өөр. Софья Александровна Варяг нөгөө хар хүнтэй нь гэртээ суухыг зөвшөөрсөн, гэтэл Нина дүүгээ тэр хүнтэй хамт байхыг харж байх тэнхэл байгаагүй. Уул нь тэр хүнийг адлах сэтгэлээ дарж, тэднийг анзаарахгүй, Софья Александровна дээр орж гардаг хэвээрээ байх нь зүйтэй байсан. Гэвч яая гэхэв, нэгэнт өөрийгөө дийлээгүй сэн хойно.

Нина ийм учир зүйтэй, үнэмшилтэй тайлбар бэлтгэжээ.

Гэвч Нина Ванягаа хөтлөн гэрэл муутай, танил өрөө рүү орж, Софья Александровна турж өтлөөд, давжаа буурал эмгэн болсныг үзмэгц, бас авдар дээр байгаа Сашагийн том зургийг хармагц өөрийн эрхгүй уйлчихав. түүний нулимс тэднийг элдвийн тайлбаргүйгээр эвлэрүүлжээ.

Тэр юунаас болоод уйлах нь тэр вэ? Өөрсдийн идэр залуу нас, хэрэгжээгүй найдвар, биелээгүй үнэн цагаан, гоё сайхан мөрөөдлөө бодоод, чин үнэнчээр итгэж байсан амьдралаа бодоод, тэр амьдралаас хөсөр хаягдсан Саша, Лена хоёрыгоо бодоод, Хувьсгалын төлөө амьдралаа зориулаад, түүнийхээ нэрээр устгуулсан Иван Григорьевич, Алевтина Федоровна нарын ахмад нөхдөө бодоод уйлсан хэрэг. Тэдгээрийн оронд арьсаа бодсон, алба дэвших хэнээтэй, мулгуу харгисууд гарч иржээ. Ийм хүмүүст захирагдах ёстой, одоо арга буюу толгойгоо гудайлгаж аж төрөх болж байна.

Софья Александровна ч Нинаг хараад бас нулимсаа барьж чадсангүй. Өнгөрсний төлөө гомдох юм байсангүй. Мэхлэгдсэн хүүхдүүд, сүйдсэн үеийнхэн, зол заяагүй улс орон. Энэ Нинагийн өвдөг рүү наалдаад байгаа цагаан жаал ч дөрөвхөн настай хэрнээ хэдийн мэхлүүлчихсэн байгаа, эцэг нь хэн, хаа байгааг мэдэхгүй, аягүй бол хэзээ ч олж мэдэхгүй байх. Бурханы ачаар л энэ хүүд Нина байна, Макс байна, ДЯАК-ын хүүхэд хуваарилах газар үхэж үрэгдсэнгүй.

Софья Александровна Ванягийн толгойг илэв.

– Ээж нь Москвад ирэлгүй их удсан, саначихсан, ирээд биднийг хараад баярласандаа уйлж байна. Ванюша, чи намайг ойлгов уу?

Хүү хариу дуугаралгүй, Нина руу асуух мэт харав.

– Худлаа гэвэл ээж нь хэлэг. Миний хэлдэг зөв үү, Нина?

Нина нүдээ арчин, нулимсаа залгих мэт болоод,

– Зөв өө, зөв гэв.

– За мэдэв үү? Чамд Москвад гоё байна уу? гээд Софья Александровна Ванягийн толгойг дахин илэв.

Хүү дахиад Нина руу харснаа, Софья Александровна руу хараа шилжүүлж,

– Гоё байна гэв.

Варя Нина, Максим хоёрыг ирээд хэд хоносны дараа гэртээ урив.

Игорь тэр хоёр Горькийн гудамжнаа, цонх нь Зөвлөлтийн талбай руу харсан шинэ байшинд суудаг аж. Цэлгэр том байр, Варя Арбатаас өөрийн дуртай ширээний чийдэн, ном, зураг энэ тэрээс юу ч авчраагүйг Нина анзаарав. Тэндхийн өрөөгөө нүцгэн болгочихыг хүсээгүй байж магадгүй.

Варя тэднийг анх ирэхэд нь галт тэрэгний буудал дээр тосохдоо Ваняг өргөөд, биедээ наан тэвэрч үнсэлсэн. Нина сандран,

– Наадахаа буулга, наад гоё хувцсыг чинь гутлаараа халтартуулчихна гэсэн.

– Халгартуулахгүй ээ, энэ чинь ухаантай хүү.

Тэгэхээр нь Ваня салгахын аргагүй нь гэхээр түүнийг тас тэвэрчихсэн.

– Хараач гэм, намайг таньж байна, санаж байх нь!

– Чи тэгж бодож байна уу? Зөндөөн их хугацаа өнгөрсөн. Чи зүгээр л наадахдаа таалагдаж л дээ. Хүүхдүүд чинь гоё хүнд дуртай байдгийг би аль хэзээний анзаарсан юм.

Варя тэднийг Арбат руу оч, тэнд хоол унд идэж, амарч хоно, өглөө нь Максим явж дотуур байрны өрөөний талаар тодруулна биз гэж ятгажээ.

Тэгээд тэдэнтэй орой болтол цуг байж, Ваняг өөрөө усанд оруулж, ор дэр засан хэвтүүлж. Үнсэж үмхлэн, чихэнд нь юм шивнэсхийн энхрийлж байгааг нь Нина хараад, энэ хүүг өөрөө аваагүйдээ харамсаж байна, эсвэл өөрөө хүүхэд байхгүйдээ харуусч байна гэж бодсон.

Нина ямар нэгэн тухайлсан санаагүйгээр, гэрлэснийг нь Саша мэдэж байгаа юу гэж Варягаас зүгээр л асууж. Варя чимээгүй байснаа,

– Мэдэж ч байж магадгүй, үгүй ч байж магадгүй, би энэ тухай мэдэхгүй гэсэн хачин хариулт өгчээ.

Тэр яриа тэгээд дуусч.

Гэтэл одоо тэднийд зочилж ирээд, Варягийн хараахан төвхнөж идээшээгүй байгаа энэ уудам цэлгэр байрыг хармагц нөгөө хачин хариулт шууд санаанд орж бүх юм хоорондоо холбогдож байх шиг болжээ. Нина буцах замдаа Максимд,

– Варя жинхэнэ ёсоор зөвхөн Сашад л хайртай байсан байх гэж надад санагдах юм гэсэн.

Игорь Владимирович тэдэнд таалагджээ: хүмүүжилтэй, эелдэг зантай тэрээр авгайнхаа хамаатнуудтай нөхөрлөх хүсэлдээ хөтлөгдөн их л найрсаг байж. Варя дээд сургуулиа төгсөөд, Игорь Владимировичийн харьяанд байдаг зураг төслийн байгууллагад зохион бүтээгч—инженерээр ажиллаж байгааг “гэр бүлэрхэх” явдлыг дэлгэрүүлж байна хэмээн инээдэм болгоцгоож.

– Алив, хоолоо идэцгээе, мах хэт шарагдчих гээд байна гэж Варя өгүүлээд, – Уух юмны тухайд Максим командлаг гэв.

Максим “Мукузани”, “Цинандали” хэмээн дарсны нэрийг уншаад, цагаан архитай лонхон дээр хараа тогтоон,

– Би бол энийг илүүд үзмээр байна гэв.

– Тэгвэл архи ууцгаая, алив Игорь хийгээрэй гэж Варя командлав.

Игорь Владимирович шилтэй архиа барин, ширээ тойрч хундагалав. Варя хундагаа өргөөд,

– За, Нина, Максим, та нарын төлөө! Эргэж ирсний чинь төлөө, та нарыг Москвад сайхан амьдрахын төлөө, Максимыг генерал болохын төлөө! гэв.

Максим цайлган инээмсэглэж,

– Генерал тэгж амархан болдоггүй юм гэв.

– Тэгвэл Будённый, Чапаев, Щорс, Котовский, өөр хэний ч тухай билээ, би кино үзсэн, тэд нар жирийн бага дарга хэрнээ арми командалж байсан, нэмэрт нь, “Бид академи мэтийг төгсөөгүй” гэж сайрхацгааж байсан шүү дээ гэж Варя зөрөв.

– Варенька хэмээн игорь Владимирович түүнийг эелдэгхэн таслаж, – Чи хундага өргөсөн, одоо ууцгаая л даа. Нина, таны төлөө, Максим, таны төлөө! гэв.

Нина Варягийн дуунд өдөөх аяс байгааг анзаараад, ярианы сэдвийг өөрчлөхөөр шийдэв. Хоолон дээр армийн тухай ярих хэрэг юу байна? Тэгээд шошыг нь магтав.

– Чи өөрөө хийгээ юү?

Варя цонхны зүг толгой дохиж,

– Үгүй ээ, ресторанд захиалсан юм, “Арагви” гэдэг гүрж ресторан, тэд нар тусгай ногоо хийдэг юм, би юу гэдгийг нь ч мэдэхгүй гэв.

Гэтэл Максим өөрөө нөгөө яриаг үргэлжлүүлэв:

– Тэгэхэд чинь өөр цаг үе байсан, Варя, өөр техник, өөр дайн, иргэний дайн. Орчин үеийн дайнд хуучин хэмжүүр таарахгүй. Хэрэв бид армид хуучирсан төсөөллөөр хандах юм бол, нүүрлээд байгаа дайнд ялагдал хүлээнэ.

Игорь Владимирович сандлаа жаахан хойшлуулж, Варягийн мөрөн дээр гараа тавиад Максим руу сониуч нүдээр харав. Одоон цагт болзошгүй ялагдлын тухай ярихын тулд шаггүй эрэлхэг зоригтой байх ёстой.

– Макс, чиний зөв, би зүгээр дүрсгүйтсэн юм гэж Варя гэмшин өгүүлэв. – Тэглээ ч гэсэн чамайг генерал болохыг, Нинад генералын авгай болохыг ерөөе. Генералын авгай эгчтэй байх чинь сайхан шүү дээ.

– Ерөөлөөр болог, би хичээнэ ээ гэж Максим түүний амыг дагуулав.

– Та дайн болохыг үгүйсгэхгүй байна уу? гэж Игорь Владимирович асуув.

– Дэлхийн дайн аль хэдийн эхэлчихээд хоёр дахь жилдээ явж байна гэж Максим товчхон хариулав.

Максим Варяд тэгж хэлсэн нь түүний өдлөг мөдлөгтэй хамаагүй, өөрийнх нь сэтгэл түгшиж байгаагаас үүдэлтэй аж. Цэргийн шилдэг дарга нарыг буудан алсны дараа Батлан хамгаалах

ардын комиссариатын удирдлагын жолоог Ворошилов тэргүүтэй Нэгдүгээр морин армийнхан гартаа авсан, тэд нар бол охорхон бодолтой, боловсрол байхгүй, иргэний дайны туршлагаар хоног төөрүүлж яваа хүмүүс. Шинэхэн мэндэлсэн маршал Кулик: улаан цэрэгт муусайн хөрөнгөтний зохиосон автомат буу хэрэггүй, жадтай винтов л байхад болоо, сум тэнэдэг, жад сүвлэдэг гэх маягийн юм хэлсэн. Бас их бууг мориор л чирэх хэрэгтэй, манай замыг туулах ямар ч техник байхгүй гэж залсан. Энэ хүн чинь Их бууны ерөнхий газрын дарга шүү дээ! Комиссариатын бусад удирдлага ч түүнээс нэг их ялгараад байх юм байхгүй. Эд нар армийг юунд л хүргэх бол?

Максим буурьтайн хувьд, аж ахуйч хүний хувьд хорооны сайн дарга байсан. Дэг журманд дуртай, түүнийгээ харгис биш хатуу гараар тогтооно. Арбатын сэхээтний хүүхдүүдийн дунд өсч, нийслэлийн шилдэг сургуулийн нэгийг төгссөн болохоор алба нэгтнүүдээсээ илүү хөгжил боловсролтой, юм их уншина, Москвагаас ном, сэтгүүл захиална.

тэрээр нээлттэй, хаалттай элдэв шүүх хуралд үнэмшихгүй, тийм явдлын цаад утга дэндүү илэрхий юм чинь. Бас Испани, Хасан нуур, Халх голын байлдаанаар соригдсон цэргийн дарга нарыг ардын дайсан гэж ердөө итгэхгүй. Гэхдээ тэднийг өмөөрнө гэдэг бол тэдний тавиланг л эдлэнэ гэсэн үг, бас эх орондоо, өөрийнхөө үйл хэрэгт зүтгэхээ болино гэсэн үг. тэрээр хэнийг ч хамгаалж өмгөөлөхгүй, бас яаж ийгээд өөрөө шүүмжлэлд эс өртөнө. Нэг хэсэгтээ тэгсхийгээд болоод байлаа. Гэтэл түүнийг хялайж хардаг болох нь тэр. Тэндээс явах хэрэгтэй, ашгүй, академийн дэргэдэх дамжаа гэж байдаг юм байна. Төрөлх хорооноосоо явмааргүй байсан ч өөр арга байсангүй.

Максим Москвад ирээд ч амар заяагаа үзсэнгүй. Энд олон найз нартайгаа уулзсан, заримтай нь Алс Дорнодод цуг алба хашиж байсан, заримтай нь цэргийн дунд сургуульд хамт сурч байсан, бүгдээрээ нэг үеийнхэн, хориод оны комсомолын гишүүд, цөмөөрөө бүхэлдээ нэг сэтгэлгээтэй. Цаг үе нь тэднийг болгоомжинд сургачихсан, гэхдээ л битүү утгаар, заримдаа инээдтэй онигоо ярих маягаар бишгүй юм ярьцгаана. Бас академид ирж лекц тавьдаг, яриа хийдэг зэвсэгт хүчний зарим дарга нар ч шүүмжлэлтэй янз бүрийн юм ярих нь бий.

Академийн профессор, багш нар ч сайн, гэхдээ гагцхүү давшина гэдэг стратеги дээр үндэслэсэн хичээлийнхээ хөтөлбөрт баригдчихна. Арга буюу ухрах, сөрж байлдах, бүслэгдсэн нөхцөлд яаж байлдах тактикийн тухай зүгээр хэлэлцэж ярилцах ч хориотой.

Улс орон маань зайлшгүй дайнд яагаад бэлтгэхгүй байна вэ? Тийм асуултыг хэн ч тавьж зүрхлэхгүй, бас хэн ч хариулж зүрхлэхгүй байсан биз.

Тэр асуултын хариуны оронд дамжааныхан Ворошиловын “ЗСБНХУ-ын батлан хамгаалалт” гэдэг номыг үг үсэгчлэн судлах ёстой. Энэ номноос:

“Социалист хувьсгалын анхны маршал, иргэний дайны фронтод байгуулсан ялалтын аугаа их маршал, коммунизмын маршал нөхөр Сталин өнөөдөр юу хийх хэрэгтэйг хэнээс ч илүү мэднэ” гэдгийг олж үзэж чадна.

“Молотов–Риббентропын” гэрээг байгуулсны дараанаас, Улаан Арми Польшт орсны дараанаас Францад Зөвлөлт Холбоот Улстай холбоотой гэж сэжиглэгдсэн орос цагаач нарыг баривчлах ажил эхэлж, зөвлөлтийн эсрэг хэвлэлийн шуугиан дэгдэж, тэр нь ЗСБНХУ-ыг Финлянд руу довтлоход дээд цэгтээ хүрэв.

Эйтингон Америк руу явахынхаа өмнө Шарокт,

– Одоо энд дайны үеийн хууль, шүүх ёс үйлчилж байгаа. Чимээгүй нуугдчих. Зборовский германуудаас айж байгаа, Парис руу явах байх гэж хэлжээ.

Эйтингон саяныхыг германаар хэлсэн аж, түүний хэлний мэдлэгийг шалгаж байгаа нь тэр. Үгүй ээ ер! Шпигельгласыг буудаад алчихсан, гэтэл түүний даалгавар хэрхэн биелэж байгааг шалгадаг байх нь: тэр хоёр цааш нь зөвхөн германаар ярьжээ.

– Тэднийг ийшээ ирнэ гэж та бодож байна уу? гэж Шарок асуув.

Эйтингон дал мөрөө хавчив:

– Германууд Парист францчууд Берлинд очихоос арай түргэн ирчихсэн байж таарна гэж бодож байна. Германууд ийшээ ирвэл тэд бидэнд цагаантнуудыг барьж өгнө гэж та бодож байна уу?

Ээ, чөтгөр чамайг, шал дэмий юм ярьж байна, германаар яаж ярьдгийг нь л сонсох гэж байгаа хэрэг.

– Энэ тухайд ямар тохиролцоо байгааг би мэдэхгүй гэж Шарок хариулав.

– Цагаантнуудыг бидэнд барьж өгөхгүй, харин орос троцкистуудыг бол өгч магадгүй. Зборовский еврей гэдгээрээ германуудад таарахгүй, троцкист гэдгээрээ оросуудад таарахгүй. Тэр эндээс явна. Танд ганц Третьяков үлдэнэ, цаашид түүнтэй барих хэлхээ холбоогоо маш болгоомжтой болгох хэрэгтэй: байр, утсаа соль, биечлэн уулзахаа боль, мэдээгээ нууц газар ашиглан авч өгч бай. Бусад бүх юмнаас хөндийр. Нэг, хоёр жилийн дараа байдлын учир олдож, манай дайсан тодорхой болно. Миний хэлснийг та ойлгов уу?

– Ойлголгүй яхав.

– Таны герман хэл нэг их гойдгүй учраас асууж байна. Та сайн дасгал хийвэл зохино.

– Хичээе ээ. Гэхдээ надад танаас асуух нэг юм байна: Герман Зөвлөлт Холбоот Улс руу довтлохыг та үгүйсгэхгүй байна уу?

– Дэлхийн хоёрдугаар дайн дөнгөж эхлээд байна, хүчний харьцаа одоогоор тодорхойгүй байна.

– Таны таамгаар бол? гэж Шарок шалгаав. Өөрийг нь төвөгтэй нөхцөл байдалд үлдээж

байгаа учраас ямар нэг баримжаа хэрэгтэй шүү дээ.

Эйтингон жаахан бодож байснаа,

– Тагнуулч хүн толгойдоо янз янзын хувилбартай байх ёстой, тэгэхгүй бол улс төрийн бодлого санаандгүй эргэхэд самгардаж мэднэ гэж хариулав.

Ингэж хэлэхийг бодоход Герман, ЗСБНХУ хоёр сөргөлдөхийг үгүйсгэхгүй байна. Нөхөр Сталин гэрээ манай ард түмэнд урт хугацааны энх амгалан байдлыг хангаж өгсөн гэж нотолж байгаа, гэтэл Эйтингон энэ энх амгалан байдал найдвартай гэдэгт итгэхгүй байна. Энэ энх тайвныг Троцкий ч найдваргүй гээд байгаа, гэтэл Эйтингон Троцкийг алахаар явж байгаа.

Эйтингон Шарок руу учиртай харав.

– Урагшаа харж байх хэрэгтэй, гол нь сүүдэрт орчих, тэгээд хотын зүгээр нэг иргэн шиг амьдарч бай. Таны сонирхох юм бол цалин, байр, оройн хоолон дээр балгах аятайхан дарс, цөөн тооны орос цагаач. Мэдээж, та эх оронч хүний хувьд Францын хувь заяаны төлөө санаа зовж байх биз.

түүнийг далд бай гэж тушааж байгаа нь яамай даа. Одоо бол алга болох шиг сайхан юм, мэдээж, алга. Ийм агенттай болно гэдэг бол англичууд, францчууд, америкчуудын хувьд хөөрхөн олз. мань хүн нэлээн юм ярьж өгч чадна, Эйтингоны тэргүүлсэн бүх сүлжээг мэдээлж болох сон. Тэгвэл ч мань хүнийг аятайхан далдлана даа. Гэхдээ хэр удаан тэгж чадах бол? Оргож ирсэн урвагчидтай нэг их нэрэлхэж цэрвээд байдаггүй: тэднээс уравсан юм чинь маниас ч урвана гээд. Хэрэгтэй юмаа хуу хэлүүлж аваад, дараа нь хөсөр хаячихна. Бас дайн яаж эргэх нь тодорхойгүй байгаа. Гэтэл Гитлер Зөвлөлттэй байлдажгүй бол? Сталинтай нийлж байгаад Англи, Франц руу дайрчихвал? Тэгсэн байхад мань хүн хаачих вэ?

Үгүй ээ, цаг нь биш байна. Эйтингоны хэлж байгаагаар бол байдал нэг хоёр жилийн дараа тодроно. Бурхан аварвал мань эр тэр хоёр жилийг амар жимэр өнгөрөөчихнө.

Шарок Венсений ойд нууц газраа шалгахад, бүх юм ёсоороо байв. Третьяковтой хотын захад уулзах тов мэдэгдээд, метронд орж, сүүлчийн вагонд сууж явсаар, зорчигчдыг бүгдийг нь харахын тулд бас хамгийн сүүлд гарч, өөр шугам руу шилжиж мөн тийм байдлаар вагоноос гарав. Араас мөрдөж байгаа шинж үгүйг мэдэж аваад, кафед орж, Третьяковтой нэг ширээнд зэрэгцэн суув.

Третьяков сүүлийн үед түгшүүрлээд байж. Зөвхөн зөвлөлтийн талыг барьдаг цагаачдыг баривчилж байгаа хэдий ч, засаг нь орос л бол бүгдийг нь хардаж, францчууд ч тэднээс нийтэд нь дургүйцэх болжээ. Харахад нэг дажгүй ноёнтон өөрийг нь дэлгүүрт явж байхад нь олон хүний нүүрэн дээр “муухай харь хүн” гэж адалсан гэж Третьяков гомдоллов. Франц хүмүүст одоо цөмөөрөнд нь оросыг адлах үзэл халдварлачихаж. Манай хааны удмынхан яаж байгааг харвал ингэхээс ч өөр яахав дээ?! Кирилл Владимирович охиноо Германы хуучин хунтайжтай суулгасан, “хуучин” нь хуучин”-тайгаа гэрлэж байна, хасах дээр хасахыг нэмвэл нэмэх гарна гэж бодож байна, энэ байдал танд хэрхэн таалагдаж байна?

Шарок ийм ярианаас учир зүйтэй юм эс олж үзээд ярианыхаа сэдвийг өөрчлөв. Биечлэн уулзахыг больж, нууц газраар мэдээ солилцох тухай түүний саналыг сонсоод өвгөн баярлав. Цөөн уулзвал эрсдэл цөөрнө. Тэр ч тийм... Гэтэл мөнгө? Шарок гурван сарын урьдчилгаа өгч түүнийг тайвшруулаад, цаашид ч ёсчлон өгч байхаа амлав.

– Үнийн өсөлтийг бодолцоно биз дээ гэж Третьяков гоншгиноход, Шарок,

– Тэгэлгүй яахав гэж хариулав.

Дөчин оны хавар Плевицкая шоронд нас барав. Үхэхийнхээ өмнө үнэн алдартны ламд нүглээ наманчилжээ... Шарок үүнээс сэрдхийв. Цагдаагийн газрын хувьд нүгэл наманчлахын нууц гэсэн ойлголт байхгүй, өрөөнд нь сонсох төрөөрөг тавьсан байж таараа. Шарок Плевицкаятай уулзаж байгаагүй. Скоблин түүний жинхэнэ нэрийг ч, хаягийг ч мэдэхгүй, байр, утсаа хоёр ч удаа сольчихоод байгаа. Харин Плевицкая Третьяковын тухай мэдэж байсан уу, үгүй юү? Үгүй гэхийн газаргүй... Скоблин сүүлийнхээ хоёр өдөр тэднийд нуугдаж байсан, Третьяков одоо аюултай, түүнийг мөрдөж мэднэ. Шарок энэ бодлоо суурин даргадаа хэлтэл, цаадах нь, ямар ч тайлбар хийлгүй Третьяковтой харилцаагаа тасал гэж тушаажээ. “Хэрэг нь гарвал олох болно”.

Мексикт юу болж байгаа нь л даанч ойлгогдохгүй байна... Үнэхээр дахиад аз дутах юм гэж үү?

Троцкийг, мэдээж, дуусгах хэрэгтэй, арван долоон онд ийм бантан хутгасан хүн. Тэр үйлдлийг Эйтингон хийнэ, бас муу юм биш, нэг еврей нөгөөгөө алж байна. Гэхдээ даалгавар биелүүлэх юм бол Эйтингон шагнуулна, бас Судоплатов, Берия хоёр ч шагнуулна. Харин Шарокт өөрт нь бол юу ч оногдохгүй! Өчүүхэн амьтан. түүний энд, энэ Парисаас хүмүүсийг тийш нь яаж эвийг нь олж явуулж, Меркадер, Сильвия хоёрыг яаж танилцуулж байсан энэ тэрийг нэхэж санах ч үгүй. Асуудлын учир шагналд байгаа юм биш, гэхдээ дэвших замд нэг юм баарлаа. Ежов түүнийг цаг нь ирэхээр Шпигельгласын дээр, тэр ч бүү хэл, Слуцкийн дээр ч тавих гэж байсан байж магадгүй, тэгэх л гэж Гадаад хэлтэст шилжүүлсэн биз, мань хүн тэгж тооцоолж байсан. Тэр тооцоо хийсэн ариллаа. Слуцкийд хор өгчихсөн, мань хүн дэвших горьдлогогүй хуучин албан тушаалдаа үлдлээ. Гомдмоор юм.

Харин Троцкийг цааш нь харуулж чадахгүй бол Эйтингоны толгой хийснэ, Судоплатовынх ч хийснэ, Бериягийнх ч хийсч магадгүй. Тэдний хамт одоогийн өөрийнх нь ивээгч Абакумов ч баларч мэднэ, тэгвэл шинэ удирдлага гарч ирнэ, шинэ хүмүүсийн аяг олох гээд үз. Тийм учраас энэ Эйтингон, Судоплатов энэ тэр нь л байж байг, арай тайван байх байлгүй. Тийм учраас Шарок ажилбар амжилттай болохыг хүсч, сонин хэвлэлийг нэгд нэгэнгүй уншивч, Мексикийн холбоотой ямар ч мэдээ байдаггүй.

Өөр санаа зовох юм Шарокт алга. Францчууд дайны тухай санааг толгойноосоо үлдэн хөөж, шинэ жүжиг, морины уралдаан, үзэсгэлэн мэтийн юм нийтлэж, тэнэгтсээр байна. Гэхдээ гудамжаар цэргийнхэн олноороо хөлхөлдөж, шөнө үдшийн цагаар гэрэл бүдгэрүүлэх журам хэрэгжиж, алдарт дуучин Морис Шевалье эх оронч шинэ дуу дуулдаг болоод байгаа. Заримдаа германы онгоц үзэгдэвч бөмбөг хаяхгүй байгаа. Шарокийн эзэн дээр ирдэг үйлчлүүлэгчид германууд Мажиногийн шугамыг давах хоншооргүй, сачий нь хүрэхгүй

маягийн юм ярьцгаана.

Гэтэл германууд эхлээд Норвеги, Дани руу, дараа нь Бельги, Голланд руу цөмрөн орлоо. Тэгснээ Мажиногийн шугамыг баруун хойгуур нь тойрч Франц руу тэмүүлж эхлэв. Францын армийн эсэргүүцэл дарагдаж, Парис хүрэх зам нээгдсэн нь тавдугаар сарын арван зургааны өглөө тодорхой болов.

Бөөн үймээн сандраан эхлэв. Ойр зуурын юмаа ачсан тэргэнцэр, хүүхдийн тэрэг хүртэл түрсэн бөөн бөөн дүрвэгсэд зүүн болон хойноос Парисыг дайран гарцгаах болов. Элдвийн юм ачсан хуучин машин, морь, үхэр, илжиг хөллөсөн тэрэгнүүд. Тэнгэрт хар манан татав. Нэг хэсэг нь хотын захад мазутын агуулах шатаж байна гэхэд, нөгөө хэсэг нь Руан шатаж байна хэмээж, гурав дахь хэсэг нь утаан хөшиг тавьж байна гэгцгээнэ.

Шарок өрөөндөө иртэл, эзэн нь бага хүүтэйгээ хөлийнхөө өрөөг цэвэрлэж байв. Уг нь тэдний цэвэрлэгч Марийгийн хийдэг ажил.

Тэгсэн чинь Мари хамаатан садныхантайгаа явна гээд өглөө халагдах тооцоо бодуулсан аж.

– Танд бас л тийм гунигтай мэдээ дуулгах нь гэж Шарок инээмэр аядав.

Шарокийн оройн хоол голдуу иддэг кафе хаагдчихаж. Хаалга нь цоожтой, цонхыг нь битүүлээд хадчихаж.

– Зүгээр, мөд учир нь олдоно гэж эзэн Шарокийг тайвшруулав.

Дуу шуу нь цоглог байна.

“Учир нь олдоно” гэдгийг германууд Парист орж ирнэ гэж ойлгох ёстой аж.

Шарокт германуудыг ирэхээс айх юм алга. Тэгэх юм бол өөрийнх нь байдал тодорхой хэмжээгээр хөнгөрнө. Холбоотнууд юм чинь. Бүтэлгүйтвэл түүнийг Москвад өгчихнө, Германы эсрэг биш, оросын цагаантны эсрэг ажиллаж байсан болохоор. Гитлертэй байгуулсан гэрээг Шарок зөв нүүдэл гэж бас сайшааж байгаа. Нацист Герман англи, францын ноёлогч баячуудаас бидэнд ойр.

Зургадугаар сарын 13-нд германууд Парисыг тойрон бүслэж Францын бусад хэсгээс салгаж байгаа нь тодорхой болов. Гадаад хэргийн яамны дээр утаа олгойдоод явчихсан нь архиваа шатааж байгаа хэрэг юмсанж. Дээд тушаалын түшмэд, ажилтан нартай урт урт хар машинаар яаран зугтацгаав. Парисыг нээлттэй хот гэж зарлаж, цэрэгтэй байлдахгүй байх тушаал өгчээ.

Шарок гэр рүүгээ сажлав. Халуун байгаа гэж жигтэйхэн. Аяга хүйтэн шар айраг залгилах сан, даанч бүх гуанз, кафе хаалттай.

Зургадугаар сарын 14-нд хотын дээгүүр германы онгоцнууд нисч өнгөрлөө.

Парис хотын цэргийн амбан захирагчийн тушаалыг радиогоор нэвтрүүлэв: оршин суугчид дөчин найман цагийн туршид гэр орноосоо гарахгүй байх ёстой, энэ хооронд германууд

Парис хотыг эзэлж дуусна. Хотын төвийн оршин суугчид германы цэрэг баярын жагсаалаар явж байгааг цонхоороо харсан аж.

Гэхдээ парисчуудын айдас амархан арилжээ. Германы цэргүүд даруухан байж. Архи уусан нь ч гэсэн гудамжны хүмүүсийг өдөж үймүүлэхгүй, дуу дуулан хөхрөлдөж, янхан хүүхнүүдтэй хуруугаа дохилцон үнэ тохиролцож байв.

Парисаас зугтагсдаас олон хүн буцаж ирж, гуанз, дэлгүүр мэт нь онгойлоо. Хотын зөвлөл, Ялалтын хаалга, Нэргүй цэргийн булш энэ тэр дээр мандуулсан хас тэмдэгтэй туг францчуудын үндэсний бахархлыг мэдээж эмзэглүүлэлгүй яахав. Гэхдээ л ер нь Герман хүчирхэг гүрэн юм, Гитлер юу хүсч байгаагаа мэдэж байна, францчууд бол мэдэхгүй, сонин дээрээ чалчаад байсан, Депутатын танхимынхан бол бүр дампуурсан. Эйтингон германууд Парисыг эзэлнэ гэж аль хэзээнээс хэлээд байсан, Гитлер Зөвлөлт Холбоот Улс руу довтлоно гээд байсан нь арай үнэн болох юм биш биз? Тэгвэл ч муу даа! Германтай байлдаж бол, ялангуяа Францыг бут цохьсон, англичууд арал дээрээ нуугдчихаад байгаа нөхцөлд тун хэцүү байх болно. Юм яаж эргэхийг харж л байхаас.

Оросын цагаачдад германууд гар хүрсэнгүй. Сталин Германд тэдний олон коммунистыг барьж өгсөн юм чинь, үгүйдээн хамгийн идэвхтэй цагаантнуудыг хариуд нь шаардана гэж Шарок бодож байж. Москва тийм хүсэлт тавьсан эсэхийг бүү мэд, лав л нэг ч орос хүн олж авсангүй. Германууд ирсэн нь орос цагаачдад харин ч ашигтай болж, олон хүнийг жолооч, байрны хаминдаа, гуанзны эрхлэгч мэтийн ажилд авч, герман хэлтэй нь хэлмэрч болцгоож.

Шарок өөрөө ч гэсэн дажгүй хэлтэй юм чинь тэднийд ажилд орж болох юм гэж бодсон боловч тэгж болох тухай удирдамж ирсэнгүй.

Троцкий алуулсан тухай мэдээ наймдугаар сарын сүүлчээр сонинд гарав. Шарок сонин хэвлэлийг сайтар судалж байгаад энэ үйлдлийн тухай овоо тодорхой төсөөлөлтэй болов.

Шарокийн Парист ивээлдээ байлгаж асан, эхлээд Жан Морнар нэртэй байгаад, дараа нь Франк Жексон болж Америк руу явсан, нөгөө Рамон Меркадер уг ажлыг хийж дөнгөсөн аж. Олон хувилбар дотроос Шарокийн бэлтгэсэн хувилбар хамгийн оновчтой нь болж таарчээ. Тэгээд мань хүн энэ тухай хэн ч эргэж дурсахгүй, гавьяа шагнал нь бусдад оногдоно гэж харамсан бодов.

Рамон, Сильвия хоёр Америкаас Мексик рүү явжээ. Рамон тэнд худалдаа наймааны ажилтай мэт байдаг, харин Сильвия нь Троцкийн нарийн бичгийн дарга нарын газартай хамтран ажилладаг болжээ. Меркадер Сильвиягийн сүйт залуугийн хувьд Троцкийн гэрээр орж гарах болж, ач хүү Севатай нь сайн болсноор хамгаалалтынхан ч түүнд дасч, саадгүй оруулдаг болсон байна. Меркадер тэднийд бага сага юмаар тус нэмэр болно, нэг удаа түүний машинаар Атлантын эргээр аялаж, дөрвөн зуун километр явцгаасан ажээ. тэрээр Троцкийтой шууд ярьж хөөрөхгүй, ойртохыг эрмэлзэхгүй, улс төрөөс хол хүний хувьд түүнээс зай барина.

Нэг өгүүллийг нь уншиж өгөөч гэсэн түүний хүсэлтэд Троцкий гайхсан боловч гэр бүлээрээ хайртай Сильвиягийн сүйт залууд татгалзах нь эвгүй гэж үзжээ. Меркадер наймдугаар сарын арван долоонд Троцкийн өрөөнд өгүүллээ аваачиж өгөхөд тэд анх удаа хоёулхнаа уулзсан

байна. Хэдхэн минут уулзжээ. Троцкий өгүүлэл дээр нь зарим нэг юм тэмдэглээд, зассан зүйлээ хэд хоногийн дараа авчирч үзүүлэхийг зөвшөөрчээ.

Наймдугаар сарын хоринд Меркадер дахин иржээ. Халуун өдөр байсан атал бүрх малгайтай, цуваа барьчихсан ирсэн аж.

– Ийм нартай байхад, та чинь юун дулаахан хувцаслаа вэ? гэж Троцкийн авгай Наталья Ивановна гайхан асуужээ.

– Энэ нэг их удахгүй, бороо орж мэднэ гэж Меркадер хариулж.

Хэрэв түүнийг цуваа өлгө гэж хэлсэн бол бүх юм илрэх байжээ. Меркадер халаасанд нь мөсний сүх, хутга хоёр байсан цуваа өгсөнгүй, тэрийг нь авгай мэдэх юм бол муу юм бодоод, дор нь хамгаалалтынхныг дуудах байсан. Тэгсэн бол тэгээд дуусах нь тэр! Мөсний сүх, хутга хоёрын тухайд хамгаалалтынхныг буруушаах аргагүй: Троцкий гэрээр нь байнга орж гарч байдаг хүмүүсийг нэгжихийг хориглож, үл итгэнэ гэдэг бол хүнийг доромжилж байгаа хэрэг гэж харуулынхандаа ухуулан ойлгуулсан аж.

Шарок энэ тухай уншаад хямсалзав. “Улаан Армийн жолоодогч бөгөөд зохион байгуулагч” иймэрхүү л төсөөлөлтэй аж төрж байж дээ. Чухам тэгээд ялагдсан байна.

Меркадер бушуухан явахын тулд машинаа хашааны цаана эргүүлээд тавьчихсаныг харуулынхан бас анзаарсангүй. Хоёр дахь машин булангийн цаана зогсож байсныг бас мэдсэнгүй. Тэр машинд Рамоны эх Каридад, Наум Исаакович Эйтингон хоёр сууж байж.

Хоёр дахь буюу сүүлчийн уулзалт бас хэдхэн минут үргэлжилжээ. Троцкий ширээ рүүгээ суугаад, өгүүлийг нь уншиж эхлэв. Меркадер цуваа ширээний булан дээр тавьж байгаад, Троцкийг нөгөө гар эх дээр нь нэг юм тэмдэглэхээр тонгойход нь сүхээ сугалаад толгой руу нь тас байлгажээ. Тийм цохилт Троцкийг нам авна, тэгээд Меркадер гэрээс гараад яваад өгч амжина гэж тооцоолсон юм байж.

Гэвч тооцоо нь бурууджээ. Троцкий муухай хашгараад босон харайж Меркадер рүү дайрахад цаадах нь түлхгэл Троцкий ойчсон боловч дэнжигнэн босч, бүдрэн барин өрөөнөөсөө гүйж гарчээ. Харуулынхан тэр даруй Меркадерийг барьж авч, гар бууны бөгсөөр балбаж алдаж. Меркадер:

– Тэд нар миний эхийг барьцаалчихсан... Би арга буюу ингэсэн... гэж арчаагүй гонгиножээ.

– Наадахыгаа битгий алчихаарай, албадаж яриулах хэрэгтэй гэж Троцкий арайхийн хэлэв.

Троцкий эмнэлэг дээр ч ухаантай байж. Тэр ч атугай, мэс засалд орохынхоо өмнө: “Маргааш үсчин ирэх ёстой юм сан, одоо түүнийг хойшлуулахаас өөр аргагүй болох нь” гэж наргиан болгож хэлжээ.

Гэвч Меркадерийн цохилт үхлийн цохилт болж таарчээ. Троцкий хорин зургаан цагийн дараа нас барсан байна.

Удаан хүлээсэн үйлдлийг эцсийн бүлэгт хэрэгжүүлжээ. Гагцхүү мөрөө яаж болхи булсан нь Шарокийн гайхшийг төрүүлжээ. Алуурчин нь “Троцкийн ойрын хүрээллийнх нь нэг этгээд” гэсэн зөвлөлтийн тайлбар бол дотоодын хэрэгцээнд зориулагдсан хувилбар. Гэтэл Меркадерийн халааснаас түүнийг Москва явж, Сталиныг алахыг Троцкий даалгасан тухай захиа олжээ. Меркадер тийм даалгаврыг биелүүлэхийг хүсээгүй учир, арга буюу Троцкийг өөрийг нь алсан ажээ. Мексикт алах ял заадаг хууль байхгүй, хамгийн том ял нь хорин жил хорих. Ямар ч тайлбар байлаа гэсэн Меркадер ийм ялыг авах байсан, тэгэхээр арай ухаалаг юм бодож олж болох байсан даа. Ер нь бол Эйтингонд тайлбар ямар байх нь хамаагүй байж. тэрээр Сталины даалгаврыг биелүүлсэн, тэгснээрээ Шпигельгласын хувь заяаг давтахаас зайлсхийж, амиа авч үлджээ.

Эйтингон, Каридад хоёр найман сар Куба, Калифорнид бүгж байгаад Хятадаар дамжин, дөчин нэгэн оны тавдугаар сард Москвад эргэж ирснийг Шарок тэртээ хойно олж мэджээ. Ажилбарт оролцсон хүмүүсийг төрийн дээд одонгоор өгөөмөр шагнасны гадна Меркадерт ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн нууц тогтоолоор Зөвлөлт Холбоот Улсын баатар цол олгожээ.

Дахиад л Казанийн галт тэрэгний буудал, Каланчевскийн талбай, олон машин, трамвай, шуудайтай, чемодантай зорчигчид, лангуу, мухлаг, миегнээн, чихцэлдээн. Гагцхүү гутал тослогч сири өвгөн л алга, муу шовгор нь ч алга.

Гурван жилийн өмнө цөллөгөөс ирэхэд эзэмдэж асан айдас хийгээд доромж сэрэл одоо алга. Бичиг баримт асуувал, би Москвагаар дамжин өнгөрч явна, ойлгов уу? Тасалбар энэ байна. Бичиг үсэгтэй биз дээ? Уншицгаа! гэчихнэ.

Ээжтэйгээ уулзаж чадахгүй нь л гомдмоор. Яваад очно гэхээр анзаарчихна, дараа нь ээжийг маань ийш тийш нь дуудаад чаргуулдчихна, тэр өлөгчингүүд юу ч хийсэн чадна. Утасдахаар хий урмыг нь хугалахаас цаашгүй. Эхлээд Калининд, дараа нь Уфад байсан, одоо Рязань руу явж байна, яагаад тэр вэ, яах гэж энэ вэ? гээд бөөн юм болно. Рязаньд очиж байгаад л утасдая, илүү сайн ажил олсон, чамд ч ойр юм гэж хэлэхээс.

Харин сургууль руу бол очно. Сургууль төгссөн тухай гэрчилгээ өгөх ёстой. Шалгалтын дүнгийн дэвтэр энэ байна, бүх хичээлийн шалгалтаа өгсөн, дүн нь тавиастай байна, онц сурч байсан, зөвхөн дипломын төслөө хамгаалаагүй. Диплом хамгаалаагүй хүнд онолын хичээлээ дүүргэсэн тухай гэрчилгээ өгдөг.

Өөрт нь тийм гэрчилгээ ямар хэрэгтэйг Саша эс мэднэ. тэрээр элдэв байгууллагад ажилд орохгүй, тэгнэ гэх юм бол биеийн байцаал, боловсон хүчний хэлтэс энэ тэр болоод явчихна. Дахиад жолоо мушгина! Тийм ажилд гэрчилгээ хэрэггүй. Хамгийн дээр нь бүжиг зааж хэдэн юм олох. Гэтэл Глеб ч алга, Семён ч алга. Бас Рязань бол Уфа биш, Москва хаяанд байгаа юм чинь үнэгэн шогшоо мэтийг сурчихаа байлгүй. Өөр л ямар нэг ажил хайх хэрэгтэй. Засмал зам тавих хайгуулын ажил, жишээ нь, юугаараа муу байхав? мань хүн авто замын дээд сургуульд сурч байсан, “Засмал зам”, “Гүүр” гэсэн хичээл ордог, геодези, топографи гээд аль алийг нь үзсэн. Өнцөг хэмжигч бариад яваад байж чадна! Тэгэх юм бол гэрчилгээ хэрэг болно. Гол нь тийм ёстой. Ёстой юм бол өгөөтөх!

Саша өөрийнхөө салбарыг олсонгүй, тусгай сургууль болгоод Ленинградын засмалын байранд шилжүүлсэн аж.

Сургуулийн захиргааныхан түүний дүнгийн дэвтрийг ч харсангүй.

– Архив руу оч, таны хувийн хэргийг тэд олог.

Архив нөгөө газар давхартаа хэвээр аж. Саша ажил явдлаа ярилаа. Гучин онд сургуульд орсон, гучин дөрвөн оны эхээр онолын хичээлээ дуусгасан, дүнгийн дэвтэр энэ байна, бүх хичээлийнхээ шалгалтыг өгсөн, дипломын өмнөх практик хийгээгүй, диплом хамгаалаагүй, гэрчилгээ өгөхийг хүсэж яваа. Сургуулийн захиргаа архиваас магадлагаа авчир гэж шаардлаа.

Архивын өвгөн гудайн байж Сашаг сонсов.

– Яагаад диплом хамгаалаагүй билээ?

– Ар гэрийн гачигдлаар Москвагаас явсан юм.

– Гэрчилгээ авья гэхгүй яагаад зургаан жил болсон юм?

– Хэрэгцээ байсангүй. Тэгээд ч Москвад энэ хооронд нэг ч удаа ирээгүй.

– Дүнгийн дэвтрээ өг дөө.

Өвгөн дэвтрийнх нь хуудаснуудыг эргүүлж үзсэнээ, хоёр гараараа ширээгээ тулж босоод, цаад биений шүүгээ рүү очиж, нарийнхан шургуулганы олон картнаас өөрийнхийг нь олоод, буцаж ирж суугаад уншиж үзсэнээ, Сашаг нэг харж дахин уншаад Сашад өгөв.

түүний карт мөн байна. Овог, нэр, төрсөн газар, он бүгд зүйтэй, сургуульд орсон жил бас зүйтэй. Гарсан шалтгаан: “Зөвлөлтийн эсрэг, хувьсгалын эсэргүү үйл ажиллагаа явуулж шийтгэгдсэний учир”.

Өвгөн одоо ширээгээ бус, Сашаг харж байв. Харцанд нь яльгүй сониуч зан, эсвэл “чиний ар гэрийн гачигдал” гэдэг чинь энэ үү гэх маягтай дооглох янз байх шиг Сашад санагдав. Тэгээд,

– Тэгээд юу гэж? гэж хэгжүүрхэхийн асуув.

– Яаж гэнэ ээ... хэмээн архивчин ойлгосонгүй.

– Ямар шалтгаанаар хамгаалаагүйг эс харгалзан гэрчилгээг диплом хамгаалаагүй бүх хүнд өгдөг.

Өвгөн түүнээс харцаа буруулж нэг хэсэг болов.

– Тэрийг чинь би биш захиргаа өгдөг юм. Би бол тийш нь бүртгэлийн картыг л шилжүүлэх ёстой.

– Алив, өгчих, би түүнийг чинь авах гэж явна.

– Гар дээр өгдөггүй юм, авах хүн захиргаанаас ирнэ. Надад эндээс гурван давхарт гарах хэцүү болчихоод байна. Энд таны хасагдсаны шалтгааныг заасан байна.

– Үүнээс болж би гэрчилгээ авах эрхгүй болж байна уу?!

– Захирал... гээд өвгөн чимээгүй болсноо, – Захирал таны эрхийн тухай биш, өөрийнхөө эрхийн тухай л бодно. Танд тийм бичиг өгөхөөсөө өмнө зөвлөлдөх байх.

Битүүдээ юу хэлж байгаа нь тодорхой. Захирал тусгай хэлтэстээ өгнө, цаадуул нь ДЯАК руу, энд нэг тийм нөхөр явж байна, юм шаардаж байна гэх маягаар утасдана. Тэгэхээр өвгөн: Саша, энэ чинь яаж эргэж мэдэхийг ойлгож байна уу? гэсэн тов тодорхой асуулт өөрт нь тавьж байна. Энэ газар давхарт, албаны энэ цэвдэг хананы дотор тэрээр эрхбиш хүн шиг хүнтэй үнэхээр уулзлаа гэж үү?

– Та Москвад суудаг уу? гэж архивчин асуув.

– Би хар дансны хүн. Том хотуудад намайг бүртгэж авдаггүй юм.

– Би таны явдлыг санаж байна, энэ чинь аль Глинскаягийн үед, Криворучкогийн үед болсон, тэгэхэд танай декан Янсон байл уу, эсвэл нөгөө... Лозгачев байл уу? Тэд нар цөмөөрөө ардын дайсан болж таарсан, юу гээчийг ойлгож байгаа биз дээ, ардын дайсан болж таарсан. Гэтэл та надад эрх байна гэж ярьж байна.

Өвгөн дахиад ширээгээ шагайчихав.

– Та хэзээ явах ёстой юм?

– Өнөөдөр.

– Танд паспорт байна уу?

– Байна.

– Үзүүл дээ.

Паспортынх хуудсыг эргүүлж үзсэнээ буцааж өгөв. Дараа нь Сашагийн карт, дүнгийн дэвтрийг нэг хавтсанд хийгээд, бас ширээгээ тулан босов.

– Явцгаая.

Тэр хоёр гурван давхар өөд, захиргаа руу өгсөв. Өвгөн шатны бариулаас барин зугуухан явахдаа, шатны тавцан болгон дээр удаан зогсож байв. Саша тохойноос нь түших гэсэн боловч өвгөн хавьтуулсангүй. Тэг тэгсээр хүрлээ.

– Энд хүлээж байгаарай.

Архивчин “Болвсон хүчний хэлтэс” гэсэн хаягтай өрөө рүү оров.

Ганц ч сандал алга. Саша танил гудаагаар нааш цааш алхав. Гудааны төгсгөлд гөлтгөнө суурин дээр улаан тугаар хүрээлсэн Лениний цээж баримал байна. Ханан дээр уриа лозун, тушаалын самбар, сургуулийн хэвлэмэл сонин, янз бүрийн зарлал...

тэрээр арван жилийн өмнө анх удаа ийшээ ирж, элсэлтийн комисст бичиг баримтаа өгч байсан. Арван жил! мань хүн одоо хорин естэй, тэгэхэд арван естэй байж...

Архивчин сонин юм түүнд дуулгалаа. Глинская, Янсон, Криворучко нарыг шоронд хийх ёстой байсан нь тодорхой. Гэтэл тэр муу алба дэвших хэнээтэй, аялдан дагагч Лозгачевыг хүртэл 58 дугаар зүйлээр заачихаж. Янсон л Сашад хамгийн хайран байв. Сайхан сэтгэлтэй шудрага хүн. Хэн нэгэн шалгалтанд уначих юм бол Янсон түүнийг “сэтгэлээ уудлан ярилцахаар” өрөөндөө дуудна:

– Улс орон таны талаар санаа тавьж, үнэ төлбөргүй сургаж байна, хүн болох боломж олгож байна, гэтэл та үүнийг үнэлэхгүй байна.

Сэтгэлийн сэвгүй хүн асан.

Архивчин боловсон хүчний хэлтсээс гарч захирал руу оров. Саша цагаа харав. Өвгөн боловсон хүчний хэлтэст нэг цаг болсон байна, захирал дээр хичнээн болдог бол?

Архивчин тэнд бүтэн хагас цаг болов. Эд нар мөн ч удаан толгойгоо зовоож байх шив, магадгүй зохих хүмүүстэй “зөвлөлдөж” байж болох. Захирал руу янз бүрийн хүмүүс орж гарч байна, гэхдээ заавал түүний асуудлаар байх албагүй л дээ. Өвгөн үүднийх нь өрөөнд нь хүлээгээд сууж байна.

Өвгөн гарч ирж Саша руу харснаа, юу ч хэлэлгүй боловсон хүчний хэлтэс рүү дахиад явлаа. Тэгснээ захирал руу буцаж ирэхийг Саша хараад, ямар нэг юм засч байна уу, эсвэл тодруулж байна даа гэж бодов.

Саша тэвчээртэй хүлээлээ. Бүтвэл сайн л биз, эс бүтвэл тэр л биз! Гэрчилгээгүй аж төрсөөр ирлээ, цаашдаа ч аж төрнө.

Тэгж тэгж өвгөн гарч ирээд,

– Энэ бол таных гээд Сашад дүнгийн дэвтрийг өгөв.

Тэгснээ албан хуудас өгч,

– Энэ бас таных гэв.

Хэвлэх үйлдвэрт хэвлэчихсэн жинхэнэ гэрчилгээ. Овог, нэрээс авахуулаад бүх юм нь ёсоор. Харин хамгийн төгсгөлд “Дипломын ажил хамгаалаагүй” гэсэн үгний дараа “Баригдсаны учир” гэсэн байв.

– Таны төлөө миний хийж чадах юм ердөө л энэ.

Баривчилсан тухай нэмж бичихийг захирал тушаасан нь мэдээж. Үхсэн хойноо! Бичгээ яг энд нь нугалчихна, яваандаа баларчихна.

Саша өвгөн рүү талархан харав.

– Танд маш их баярлалаа, салаад явах болох нь, таны нэр хэн юм бэ?

– Нэрээр яах гэв? Баяртай, сайн сайхныг хүсье.

Өвгөн шат руу эргэн уруудав.

Саша сургуулийн байрнаас гарав. Эндээс галт тэрэгний буудал орно, тэндээс Рязань. түүнийг Рязаньд юу хүлээж байгаа бол? Сургууль дээр аз дайрлаа, Рязаньд ч бас аз дайрах юм бил үү?

Ийнхүү, Сталин генерал, маршалуудаараа сэтгэл дүүрэн байж болохоор байна: дуулгавартай, гүйцэтгэл сайтай, улс төр рүү зүтгэлэхгүй, хүн болгоны нууж хааж явдаг юмыг нь мань хүн мэдэж байгааг Васильевскийтэй ярилцсанаас нь ойлгоцгоосон.

Германы үйлдэл нэг их тодорхой биш байна. Цэргээ Румын, Финляндад байрлууллаа, Япон, Итали хоёртой “Гурвын гэрээ”-нд гарын үсэг зурлаа. Япон Германы цэргийн холбоотон боллоо, энэ бол ЗСБНХУ баруун талдаа дайн хийх болвол дорно зүгт нь хоёр дахь фронт бий болно гэсэн үг.

Молотовын асуулгын хариуд Риббентроп Зөвлөлт Холбоот Улсыг “Гурвын гэрээ”-нд нэгдэж, түүнийг “Дөрвийн гэрээ” болгохыг санал болгосон. Гэхдээ энэ нь Зөвлөлт Холбоот Улсыг Англи, АНУ-тай цэргийн сөргөлдөөнд татан оруулна, ЗСБНХУ үүнд бэлэн бус байгаа. Цаг хожихын тулд сунжирсан дипломат яриа хэлэлцээ эхлүүлэхээр шийджээ.

Молотов арван нэгдүгээр сарын 12-нд Берлинд ирж, Гитлертэй хоёр удаа уулзав. Гитлер зөндөөн удаан ярихдаа, Англи тун удахгүй бут цохиулна, Герман, Зөвлөлт хоёр Япон, Италийн хамт Британийн өвийг хувааж авах болно гэж баахан нотлов. Финлянд, Румынд байгаа Германы цэргийн тухай, Хар тэнгисийн хоёр хоолойн тухай, Балканы байдлын тухай ярих гэж Молотовын оролдоход Гитлер сонсох ч үгүй зувчуулан, нөгөө л бүх дэлхийг хуваах тухайгаа бураад байжээ.

Гитлертэй хийсэн яриа ямар ч үр дүн өгсөнгүй. Риббентроп Молотовыг үдэж өгөхдөө:

– Британийн эзэнт гүрнийг устгахад Зөвлөлт Холбоот Улс бидэнтэй хамтарч ажиллахад бэлэн байна уу, үгүй юү гэдэг л үндсэн асуудал. Бусад бүх юм туйлын өчүүхэн асуудал гэж хэлжээ.

Энэ үгэнд хариу хэлэх хэрэгтэй болов. Тэгээд бас л хариу өгөхүй удааж, тэр хооронд биеэ даан Японтой харилцаагаа зохицуулна гэж шийдсэн аж. Япон Индонези, Малай, Сингапур, Бирма рүү дайрах гэж байгаа, тэгэхээр өөрийгөө ЗСБНХУ-ын зүгээс аюулгүй болгох ёстой нь мэдээж.

1941 оны дөрөвдүгээр сарын 13-нд ЗСБНХУ, Япон хоёр төвийг сахих тухай гэрээ байгуулав. Сталин бөөн баяр хөөр. тэрээр Гитлерийн далд санааг тааж мэдсэнээ түүнд дахин харууллаа. Гитлер түүний яадгийг үзэх гэж зарим нэг алхам хийж байна. Улс орон, ард түмнээрээ бод хийсэн шатрын өрөг гэлтэй. түүний хариу нүүдэл болгон Гитлерийн бахархлыг төрүүлж байгаа нь дамжиггүй: өөрт нь дүйсэн өрсөлдөгч, таарсан холбоотон.

Гэрээнд гарын үсэг зурсан Японы гадаад хэргийн сайд Мацуокаг Москвагаас явахад Ярославлийн буудлаас хөдлөх галт тэргийг түр саатуулжээ. Мацуокаг үдэж гаргахаар Сталин өөрөө иржээ. Энэ бол зөвлөлт төрийн түүхэнд болсон ганцхан тохиолдол. Үүнээс өмнө Сталин гадаадын төлөөлөгчдийг хэзээ ч тосох юм уу, үдэж байгаагүй. Буудал дээр Сталин Шуленбургийн мөрөн дээр гараа тавиад, Мацуокад хандан: “Бид анд нөхөд чигээрээ байх ёстой, үүний тулд бүхнийг хийх ёстой” гэж ёслол төгөлдөр хэлэв. Бас Германы цэргийн

агташе Кребстэй гар барьж, “Бид анд нөхдөөрөө байна” гэж сайхан загнажээ.

Ийм ёслолын дараа галт тэрэг хөдлөж, Мацуока тусгай вагондоо орсон хойно, одоо бий болоод байгаа нөхцөл байдлыг тайван эрэгцүүлж бодох боломжтой болов. Сталин хэдийгээр тагнуулын айхтар сүлжээтэй ч энэхүү нөхцөл байдлыг мэдэхгүй, юу ч гадарлахгүй байгаа бололтой. Мацуока гэрээнд гарын үсэг зурахын өмнө Берлинд очихдоо Гитлертэй уулзахад, цаадах нь: “Хэдэн сарын дараа ЗСБНХУ-ыг их гүрнийх нь хувьд дуусгавар болгоно” гэж мэдэгджээ. Мөн тэгэхэд Мацуока ЗСБНХУ-тай гэрээ байгуулж магадгүй тухай Риббентропт мэдээлэхэд, татгалзсан зүйл юу ч хэлээгүй. Тэгэхээр Гитлерт ЗСБНХУ-ын эсрэг холбоотны хэрэг байхгүй, түүнийг өөрөө дөнгөнө гэж найдаж байх нь. Мацуока бас Улаан Армийн штабын дарга генерал Жуковт бараалхсанаа санав. Тийм уулзалт хийх хүсэлт зөвлөлтийн талд санаандгүй зүйл байсан боловч Мацуока тийм уулзалт хийх завал хэрэгтэй гэж үзсэн билээ. Герман удахгүй довтлох гэж байгаа тухай Сталин, Молотов хоёр үнэхээр мэдээлэлгүй байна гэж үү? Хашир улс төрчид түүний өмнө яаж ч жүжиглэсэн чадна. Жуковыг таамаглахад арай амар байх биз. Жанжин штабын дарга дайны өмнө юу бодож байж болох вэ? Мэдээж дайны тухай. Жуков дээрээс тушаасны дагуу эелдэг байх гэж дүй муутай оролдсон цэрэг гэж харагдсан хэмээн Мацуока Токиод ирээд илтгэжээ. Жуков хилийн чанадад хэзээ ч байгаагүй, харин Герман, Итали, Английн тухай их юм уншсан, гэхдээ улс орныг номоор бус өөрөө очвол таньж мэдэхэд илүү амар гэхчилэн хээгүй юм ярьсан аж. Гэтэл нүүрлээд байгаа дайны тухай Жуков мэдэж байгаа эсэхийг Мацуока бас л ойлгосонгүй.

Сталин Японтой гэрээ байгуулсандаа сэтгэл хангалуун байв: Зөвлөлт Холбоот Улсад хоёрдугаар фронт байхгүй, тэгэхэд Германд байна, тэр нь Англи. Тийм учраас Гитлер Английг янзлахаас нааш ЗСБНХУ руу довтлохгүй. Мэдээж, түүнд шалтаг өгөхгүй бол, Гитлертэй итгэмжилсэн, найрсаг харилцаагаа бэхжүүлээд байвал довтлохгүй. Тэгэхийн тулд улсын албан ёсны тэргүүний хувьд өөрөө бодлогоо тодорхойлох ёстой. Сталин тавдугаар сарын эхээр Ардын Комиссариатын Зөвлөлийн дарга болж засгийн газрыг тэргүүлэх болов. Молотов гадаад хэргийн сайдаар үлджээ.

Сталин Герман Зөвлөлт Холбоот Улс руу довтлохоор бэлтгэж байгаа тухай нэг ч мэдээлэлд урьдын адил итгэхгүй байв. Бодол удаантай Молотов хүртэл Улс төрийн товчооны хурал дээр:

– Тагнуулчдад найдаж болохгүй. Тагнуулчид хожим учрыг нь олохын аргагүй аюултай байдал руу түлхэж мэднэ. Өдөөн хатгагчид энд тэндгүй тоо томшгүй олон байна гэж залжээ.

Зүйтэй хэлсэн. Манай гадаадад байгаа тагнуулуудын тал хувь нь дайсны талд элсчихсэн, тэгээд тэр эздэд нь хэрэгтэй юмыг л мэдээлж байгаа.

Гэтэл зөвхөн тагнуулчид төдийгүй манай цэргийн дарга нар германы цэргийн ангиуд ЗСБНХУ-ын шинэ хил дээр бөөгнөрч байгаа тухай, танк, их буу, элдэв машин, зэр зэвсэг ачсан цуваа хилийн зүг тасралтгүй хөвөрч байгаа тухай, хил зөрчиж байгаа тухай, германы онгоц зөвлөлтийн нутгийн гүн рүү тагнуулын нислэг байнга хийж байгаа тухай мэдээлж байна. Ийм өдөөн хатгалгыг яагаад няцаахыг зөвшөөрөхгүй байна? гэж олон дарга нар гайхаж байна. Жуков хүртэл түүнд тийм асуулт тавьж зүрхэлсэн.

Тэглээ гэж Сталин Жуковыг зад загнасан боловч засгийн газрын тэргүүний хувьд Гитлерт

хувийн илгээлт бичиж, германы цэрэг зөвлөлтийн хил дээр бөөгнөрч байгаад тэрээр гайхаж байна, Герман Зөвлөлт Холбоот Улстай байлдах гэж байгаа мэт сэтгэгдэл төрж байна гэж мэдэгджээ. Гитлер хариуд нь мөн хувийн илгээлт нэн даруй ирүүлж, түүндээ: ноён Сталин зөв мэдээлэлтэй байна, Польшт үнэхээр томоохон цэргийн нэгтгэлүүдийг төвлөрүүлсэн байгаа, гэхдээ тэр нь Зөвлөлт Холбоот Улсын эсрэг чиглээгүй, өөрөө, Гитлер, байгуулсан гэрээгээ чандлан сахина, үүнийг улсын тэргүүний нэр төрөөр батлан илэрхийлж байна гэж, түүний онцлон цохсоноор, итгэмжлэн мэдэгджээ. Үүний шалтгаан нь Германы нутаг дэвсгэрийг англичууд хүчтэй бөмбөгдөж байгаа, тийм учраас тэрээр цэргээ дорно зүгт арга буюу шилжүүлэн байрлуулсан аж. Энэ мэдээлэл Сталинаас цааш гарахгүй гэж Гитлер найдаж байгаа гэнэ.

Энэ бол илэн далангүй, нөхөрсөг, үнэмшилтэй хариу, гол нь, тагнуулчдад итгэж болохгүй гэсэн түүний итгэл үнэмшилтэй таарч байна.

Гэтэл Берлинээс ирсэн зөвлөлтийн элчин сайд Деканозовыг германы элчин сайд Шуленберг урьж цайлах зуур, элчин сайдын яамны зөвлөх Хильгерийн дэргэд ингэж хэлжээ:

– Ноён элчин сайд аа, ийм юм дипломатын түүхэнд байгаагүй байх, гэхдээ би танд төрийнхөө нэгдүгээр зэргийн чухал нууцыг уламжлах гэж байна. Гитлер зургадугаар сарын хорин хоёронд ЗСБНХУ-ын эсрэг дайн хийж эхлэх шийдвэр гаргасныг ноён Молотовг мэдээлнэ үү, түүнийг цааш нь ноён Сталинд мэдээлнэ гэж найдаж байна. Намайг яагаад ингэж байгааг та асууна. Би бол Бисмаркийн үзэл санаагаар хүмүүжсэн хүн, Бисмарк хэзээ ч Оростой дайтахын эсрэг байсан юм гэжээ.

Энэ тухай Сталинд илтгэжээ. Улс төрийн товчооны хурал дээр Сталин,

– Төөрөгдүүлэх мэдээллийг бүр элчин сайдын түвшинд хийдэг болчихож гэж үзэцгээе хэмээсэн ажээ.

Төөрөгдүүлэх мэдээлэл үнэхээр элчин сайдын түвшинд явж байна гэж Улс төрийн товчооны гишүүд бүгд санал нийлэв.

Ингээд тагнуулын мэдээ, цэргийн дарга нарын мэдээлэл Сталины зөвхөн дургүйг хүргэх болжээ.

Японд байсан “Рамзай” гэдэг нууц нэртэй зөвлөлтийн тагнуул Рихард Зорге Риббентропын элчин сайддаа ирүүлсэн цахилгааны фото хуулбарыг Москва руу дамжуулжээ. Тэр цахилгаанд Герман ЗСБНХУ руу хийх довтолгоогоо зургадугаар сарын хоёрдугаар хагаст хийхээр төлөвлөсөн гэсэн байж.

Яг энэ тухай Черчилль өөрийн элчин сайдаар уламжлан Сталиныг сэрэмжлүүлсэн байна.

Зургадугаар сарын 11-нд Москвад суугаа Германы элчин сайдын яамны ажилтан Герхард Кегель, элчин сайдын яамны нууц бичиг баримтыг устгаж, долоо хоногийн дотор нүүх бэлтгэл хангах тушаал Берлинээс ирсэн тухай нууцаар мэдээлсэн байна.

Зургадугаар сарын 12-нд Швейцарт байгаа зөвлөлтийн тагнуул Радо: “Довтолгоо зургадугаар сарын 22-ны ням гаригийн үүрээр эхэлнэ” гэж урьдчилан сануулжээ.

Гэтэл зургадугаар сарын 14-нд сонин хэвлэл, радиогоор зөвлөлтийн ард түмэнд: “Герман Зөвлөлт Холбоот Улсын нэгэн адил үл довтлолцох тухай зөвлөлт-германы гэрээний болзлыг хэлбэрэлтгүй сахиж байна. Иймийн учир, зөвлөлтийн талын үзэж байгаагаар бол Герман гэрээг зөрчиж, ЗСБНХУ руу довтлох гэж байгаа тухай цуурхалд ямар ч үндэс байхгүй юм” гэсэн албан ёсны мэдээ түгээжээ.

Зургадугаар сарын 15-нд Японоос, Зоргегоос: “Довтолгоо зургадугаар сарын 22-ны үүрээр өргөн фронтоор эхэлнэ” гэсэн шинэ цахилгаан иржээ.

Мөн тэр өдөр Тимошенко, Жуков хоёр Сталин дээр ирж, Гитлер довтлох гэж байгаа тухай сүүлийн үеийн багц мэдээллийг гардуулав.

Сталин тэдгээрийг гүйлгэн хараад, ширээн дээр тоомсоргүй хаяж, өөр нэг хавтас руу зааж,

– Энэ бүх элий балай юмыг чинь надад аль хэзээний илтгэсэн. Түүгээр ч барахгүй, Японд үйлдвэр завод, янхны газартай болчихсон манай нэг муу эрваа тээрхий өнөөдөр германы довтлох өдрийг хүртэл хэлж байна: зургадугаар сарын хорин хоёронд дайрах юм гэнэ. түүнд итгэ гэж тушаацгаах уу, та нар? Явж ажлаа хийцгээ. Бас захиргаандаа байдаг хүмүүст уймарч сандралдахыг хатуу хоригло. Хар л даа, Баруун зүгийн цэргийн тойргийн командлагч Павлов: “Улсын хилийн дагуух хээрийн бэхлэлтэнд байраа эзлэхийг зөвшөөрнө үү” гэж гурав дахь удаагаа цахилгаан ирүүлж байна. Генерал Павлов дайн өдүүлэх гээд байна гэж та нарт санагдахгүй байна уу?

Жуков зүрхлэн хариулав:

– Нөхөр Сталин, генерал Павловыг хардах үндэс бидэнд байхгүй. Шалгагдсан хүн. Мэдээж, анхаарал болгоомжтой л доо.

– Болгоомжлох шалтгаар дайсанд яггүй тус хүргэж болно хэмээн Сталин түүний үгийг таслав. – Хэрэв Павлов ямар нэгэн дур мэдсэн үйлдэл хийх юм бол та нар толгойгоороо хариуцна шүү. “Анхаарал болгоомжтой” гэнэ! Павлов анхаарал болгоомжтой, засгийн газар намын Төв Хороо анхаарал болгоожгүй юм уу?

Тимошенко, Жуков хоёр дуугарсангүй.

– Тэгэхээр ийм байна, Павловт энэ мэт цахилгаан нааш нь явуулахыг бүр тас хоригло. Тэр ойлгохгүй байгаа юм бол, цэрэг шилжүүлэн байрлуулна гэдэг бол ердөө германуудыг өдсөн хэрэг болно гэдгийг түүнд тайлбарлаж өг.

Зургадугаар сарын 16-нд Германаас нууц тагнуулын мэдээ ирэв:

“Зөвлөлтийн эзлэгдсэн нутагт янз бүрийн албан байгууллагыг толгойлохоор томилогдсон 2500 гаруй хүний зөвөлгөөн Дрезденд болов”. Мөн Москва, Петербург, Киев, Минск, Тбилис

хотуудын ирээдүйн дарга нарын нэрийг хэлж байсан байна.

Сталин Улсын аюулаас хамгаалах ардын комиссар Меркулов, тагнуулын газрын дарга Фитин хоёрыг дуудахыг тушаасан ёсоор тэд хэдхэн минутын дараа Кремльд иржээ. Сталин тэднийг суу гээгүй тул үүд хавьд зогсоцгоов.

Сталин өрөөн дундуураа холхих зуур Фитинийг нэр усгүй мэт,

– Тагнуулын газрын дарга аа, үүнийг ямар эх сурвалж мэдээлж байна вэ, хэр зэрэг найдвартай юм бэ, тэд ийм нууц мэдээ авах ямар боломжтой юм бэ, үүнийг илтгэнэ үү гэв.

Фитин тагнуул нэг бүрийн тухай дэлгэрэнгүй танилцуулав.

Сталин дуустал сонсоод өрөөн дотуураа удаан явсны эцэст,

– Тэгэхээр ийм байна, тагнуулын дарга аа. Вильгельм Пикээс өөр итгэж болох герман байхгүй. Мэдэв үү? гэв.

Зургадугаар сарын 21-нд Алфред Лисков гэгч герман цэрэг хил нэвтрэн ирж, германы арми маргааш өглөө дөрвөн цагт довтолж эхэлнэ гэж мэдэгджээ. Их буу галын байраа эзэлсэн, танк, явган цэрэг довтлох шугам дээр ирсэн гэж.

Энэ тухай Сталинд илтгэжээ. тэрээр Тимошенко, Жуков, Ватугин нарыг нэн даруй ирэхийг тушааж. Тэднийг ирэхэд Улс төрийн товчооны гишүүд ширээний ард хэдийнэ сууцгаасан байв.

– Мөргөлдөөн өдөөхийн тулд германы генералууд энэ босуулыг явуулсан юм биш биз? гэж Сталин асуув.

– Үгүй, энэ босуул үнэн юм хэлж байна гэж бид үзэж байна гэж Тимошенко итгэлтэй хариулав.

– Бид юу хийх ёстой болж байна? гэж Сталин асуув.

Жуков хил дээрх бүх цэргийг байлдааны бүрэн бэлэн байдалд оруулах, аливаа довтолгооныг шийдвэртэй няцаах тухай удирдамжийн төслийг уншив.

Сталин түүнийг таслаж,

– Ийм удирдамж өгөх эртдэнэ. Бүх юмыг эвийн аргаар зохицуулахыг хичээе. Элдэв төвөг үүсгэхгүйн тулд манай цэрэг ямар ч өдөөн хатгалгад автах ёсгүй гэв.

Цэргийнхэн шинэ удирдамж бэлтгэхээр явцгаав. Улс төрийн товчооны гишүүд бараг өглөө болох гэж байхад гэр гэр рүүгээ явцгаав. Сталин зуслан руугаа явжээ.

Хаалга цохих чимээнээр Сталин сэрэв.

– Нөхөр Сталин, армийн генерал Жуков тантай яаралтай хэргээр ярихыг хүсч байна.

Сталин утсаа авч,

– Сонсож байна гэв.

– Нөхөр Сталин, тун сая германы онгоц Минск, Киев, Вильнюс, Брест, Севастополь болон бусад хотыг бөмбөгдлөө хэмээн Жуков илтгэв.

Сталин дуугарсангүй.

– Та намайг ойлгов уу, нөхөр Сталин?

Сталин хариу байдаггүй.

– Нөхөр Сталин, та намайг ойлгов уу? гэж Жуков дахин асуув. – Та намайг сонсож байна уу, нөхөр Сталин? Байна уу, байна уу! Нөхөр Сталин, та хариулж болгооно уу, та намайг сонсож байна уу?

Сталин тэгж тэгж сөөнгөтсөн дуугаар,

– Тимошенкотой Кремль рүү оч. Улс төрийн товчооны гишүүдийг цуглуул гэж Поскребышевт дамжуулаарай гэв

Тийнхүү, Герман дөчин нэгэн оны зургадугаар сарын 22-ны өглөөний дөрвөн цагт дайнд бэлэнгүй байсан, энэ дайнд хорин долоон сая хөвүүд, охидоо алдсан Зөвлөлт Холбоот Улс руу довтлов.

Нойр дутуу, цонхигор царайтай Сталин Кремлийнхээ албан өрөө рүү орлоо. Улс төрийн товчооны гишүүд түүнийг хэдийнэ хүлээж байв. Тайван царайлцгааж байгаа нь худлаа. Нөхөр Сталин бидэнтэй байгаа цагт бүх юмны учир олдоно гэж байгаа юм биз дээ, ухаан нь. Худлаа тэгж царайлцгааж байг, эд нар өөр юу чаддаг сан билээ дээ?

Тийм тодорхой, алсын хараатай, олон жил тээсэн, Гитлер тэр хоёрын хувьд байж болох цорын ганц бодлого нь сүйрэн нурлаа. Хэн үүнийг нураав? Гитлер өөрөө юу? Тийм байх ёсгүй, Берлинд төрийн эргэлт гараа юу? Английн ноёлогч баячуудад худалдагдсан германы генералууд дайн дэгдээж, луйварчин Черчилль цохилтыг өөрөөсөө зайлуулав уу? Тодорхой болгох шаардлагатай.

– Германы элчин сайдын яам руу утасдах хэрэгтэй гэж Сталин хэлэв.

Молотов утас руу очиж, нэг хүнтэй яриад, утсаа тавилгүй Сталин руу эргэж,

– Германы элчин сайд яаралтай мэдээлэл хийхээр өөрийг нь хүлээж авахыг хүссэн байна гэв.

Молотов түүн рүү асуусан царайтай харзнав. Шуленбургийг нөхөр Сталин хүлээж авах ёстой гэж үзэж байгаа нь андашгүй байна. Үгүй шүү, Сталин түүнтэй ярилцахгүй, тийм шалтгаанаар учир зүй хэлэлцэх, тэр германаас тийм мэдээ сонсох бодолгүй байна.

– Чи уулз гэж Сталин хэлэв.

Молотов утсаа тавиад өөрийнхөө өрөө рүү очив.

Генерал Ватугин ирж, германууд их буугаар цочирдуулах буудалт хийсний дараа Баруун болон Баруун хойд фронтын бүх шугамаар давшиж эхэлсэн тухай илтгэв. Гэвч энэ арганд тэрээр хууртахгүй. Энэ үнэхээр дайн юм бол, германууд манай анхаарлыг өмнө зүгээс хөндийрүүлж байна, тэд тийш нь гол цохилтоо бэлтгэж байгаа.

Молотов буцаж ирэв.

– За яав? гэж Сталин асуув.

– Герман манайд дайн зарласан байна.

Сталин босч, өрөөнийхөө тэртээ буланд очоод цонхон тус зогсов. Тэгэхээр, генералууд биш, хуйвалдагсад биш, британийн тагнуулууд биш, Гитлер гэдэг нэг муу гоншгоносон шаар түүнийг мэхэлжээ. Европт байгуулсан ялалтандаа ташуурчихаж. Гэвч Зөвлөлт Холбоот Улс бол Европ биш, манай гаригийн зургааны нэг, муусайн германууд Оросоор зугаалцгааг. тэрээр дайныг хүсээгүй. түүнийг албадаж байна, тэрээр дайтах болно.

Жуков бослоо.

– Хил орчмын тойргуудад байгаа бүх хүчээр дайсан руу нэн даруй уулгалан дайрч, урагшлан

давшихыг нь зогсоохыг Жанжин штаб санал болгож байна.

Сталин дуугарсангүй.

Тимошенко Сталиныг Жуковоос илүү мэдэх учир,

– Зогсоох биш устгах гэж тодруулав.

Сталин толгой дохив.

– Удирдамжаа өгцгөө.

Цэргийнхэн гарцгаав.

– Дайны тухай ард түмэнд мэдээлэх хэрэгтэй, хэлэх үгээ бэлтгэ! гээд Сталин Молотов руу харав.

Зовлонтой чимээгүй байдал үүсэв. Сталиныг өөрөө үг хэлнэ гэж бүгд итгэл төгс байж.

– Нөхөр Сталин хэмээн Вознесенский зүрхлэн ам нээв. – Ийм түүхэн хариуцлагатай мөчид ард түмэн юуны өмнө танаас үг дуулах ёстой.

– Хэнээс дуулах нь ямар ялгаа байна?! Совнаркомын даргаас юм уу, түүний орлогчоос? Ард түмэн Молотовыг мэднэ.

– Ард түмнийг улс орноо хамгаалах тэмцэлд зөвхөн нөхөр Сталин л босгож чадна гэж Каганович хэлэв.

– Яагаад нөхөр Сталин үг хэлэхгүй байгааг ард түмэн ойлгохгүй гэж Микоян нэмэв.

– Ард түмэн дайн эхэлж гэдгийг ойлгоно, энэ л гол юм гэж Сталин хариулав.

– Тэглээ ч гэсэн нөхөр Сталин үг хэлбэл зүгээр сэн. Мэдээж, ард түмэн нөхөр Молотовыг мэднэ, гэхдээ ард түмэн жолоодогчийнхоо дуу хоолойг, нам, засгийн жолоодогчийнхоо дуу хоолойг сонсох ёстой гэж Калинин хүч нэмэв.

Өөрийг нь урдаа барих нь, өөрсдөө ард нь зогсож байх юм гэнэ. Одоо түүнд хэлэх юм юу ч алга байгааг ухаарах чадалгүй шүү, өөрөө бол мэдээлэх биш, дайн болохгүй гэж удаа дараа нотлон хэлсээр атал яагаад дайн эхэлснийг тайлбарлах ёстой, тэр тайлбарыг бодож олох ёстой. Хэд хоногийн дараа, дайсныг ухрааж, Улаан Арми түүнд хүчтэй цохилт өгч, буцааж хөөсний дараа мань ХҮН үг хэлнэ.

Сталин хөмсөг зангидав.

– Нөхөр Молотов ард түмний өмнө олон удаа үг хэлж байсан, германы хэрэг явдлын талаар их ярьж байсан. Молотов үг хэлэх нь учир зүйтэй, ард түмэнд ойлгогдоно. Хэлэх үгээ бич, Вячеслав.

Эцэст Молотов хэлэх үгийнхээ төслийг уншив. Сталин анхааралтай чагнав. Молотовын хэлэх үг бол, хүн төрөлхтөнд, түүхэнд хандсан түүний үг байх болно.

Тийм учраас хэд хэдэн газар дараах зүйл нэмэхийг тушаалаа:

“Ямар ч гомдол санал мэдүүлэлгүйгээр германы цэрэг манай орон руу дайрлаа”.

“Зөвлөлт засгийн газар гэрээний болзлыг маш үнэнчээр биелүүлж ирснийг үл харгалзан”.

“Германы засгийн газар ЗСБНХУ-д нэг ч гомдол гаргах үндэс байгаагүй”.

“Манай цэрэг, манай нисэх хүчин нэг ч цэгээр хилийн зөрчил гаргаагүй”.

Энэ хэлэх үг хэдийгээр: “Манай аугаа их жолоодогч Сталиныг хүрээлэн эгнээгээ улам нягтруулъя” гэсэн уриа, мөн: “Манай үйл хэрэг зөв. Дайсан бут цохиулна. Бид ялахдаа л нэг ялна” гэсэн үгээр төгсөж байгаа ч, бүхэлдээ энэ үг Сталины хүссэнчлэн, Гитлерийг хорон санаалж, итгэл эвдсэн хэмээн буруутгасан ял болон сонсдож байв.

Улс төрийн товчооны нэг ч гишүүн Сталины засварыг эсэргүүцэж эс зүрхлэв.

Энэ хооронд хил дээрээс түгшүүрт мэдээ ирсээр байлаа. Дайсан баруун болон баруун хойд талаар давшин урагшилсаар байгаа ч, Сталин үүнийг төөрөгдүүлэх арга, Гитлер гол цохилтоо өмнөд чиглэлээр хийнэ гэж итгэсэн хэвээр тул Жуковт,

– Тернополь руу, Баруун өмнөд фронтын штаб руу нэн даруй нисч оч гэж тушаав.

– Ийм ярвигтай үед Жанжин штабыг хэн удирдах болж байна?

– Өөрийнхөө оронд Ватутиныг үлдээ гэж Сталин хэлээд, – Та цаг алдах хэрэггүй, бид энд яаж ийгээд болно гэж эгдүүцэв.

Жуков Киев рүү нисч, орой болоход Тернопольд хүрэв. Яг тэгтэл Ватутин утасдаж Сталины удирдамжийг уншиж өгөв: цэргээ дайсныг бут цохиж, түүний нутаг дэвсгэр рүү орох сөрөг дотолгоонд оруул. Энэ удирдамжинд Жанжин штабын даргын хувьд Жуковын гарын үсэг хэрэгтэй.

– Юун сөрөг довтолгоон бэ? гэж Жуков хашгачив. – Байдлын учрыг олох хэрэгтэй байна, өглөө болтол хүлээж байгаарай.

– Тантай санал нэг байна, гэхдээ энэ бол шийдчихсэн асуудал гэж Ватутин хариулав.

Юун сөрөг довтолгоон, тэр тухай ярихын ч хэрэг байхгүй. Зөвлөлтийн цэрэг хамгаалалтанд бэлэн бус байгаа. Фронт дээр эмх замбараагүй байдал ноёрхож байв. Сталины тушаалаар хуучин хилийн зэвсэглэлийг хураасан, гэхдээ шинэ хил дээр суурилуулж амжаагүй аж. Нөхөр Сталин Гитлер зөвхөн ирэх жил довтолно, тэгэхдээ гол цохилтоо өмнөд чиглэлээр өгөх гэж оролдоно гэж хэлсэн шүү дээ. Гэтэл Гитлер энэ жил довтоллоо, тэгэхдээ гол цохилтоо өөрийн тав-зургаа дахин илүү хүчтэй баруун чиглэлээр өглөө. Энэ бол утгагүй, балай

удирдамж, гэвч Жуков Сталиныг сөрж зүрхэлсэнгүй.

– За яахав, миний гарын үсгийг тавьчих.

Ватутин Сталины өрөөнд дахин ирж, германы танкийн цуваа Минскээс холгүй байгааг илтгэв.

– Та юу гэж будилаад байна? Дайсан тав хоногт хоёр зуун километр явчихаа юу?

– Тэглээ, нөхөр Сталин, Баруун фронт сэт цохиулсан.

Сталин ширээ шаав.

– Жанжин штаб цэргээ ингэж удирддаг байх нь ээ! Та нар дайсан Минскт ойртоод ирсэн хойно фронтын байдлыг мэдэж авч байна! Маргааш орж ирээд, дайсан Москвад ойртоод ирж гэж хэлэх нь ээ дээ! гээд Сталин зургийг түлхэн зайлуулж, – Энэ хүүхэд нохойн наадмаа ав, хоёр цагийн дараа надад фронт дээрх манай болоод германы цэргийн байрлалыг яг харуулсан зураг танилцуул гэж зандрав.

Германууд Минскийг эзэлж авах уу?! Үүнд итгэхийн арга алга! Минск рүү германы хэдхэн танк цөмрөн орсон байж магадгүй, тэгээд л Жанжин штабынхан бажгадчихаа биз?

Сталин Тернополь руу утасдаж, Жуковтой холбоо барив.

– Нөхөр Жуков! Баруун фронт дээр хүнд байдал бий боллоо. Дайсан Минск рүү дөхөж ирлээ. Павлов юу болсон нь ойлгомжгүй байна. Та Москвад ир.

Нойргүйдээ нүд нь улайж, царай алдсан Тимошенко, Жуков, Ватутин гурав шөнө Сталины өмнө номхон зогсож байв.

Сталин Баруун фронтын зургийг ширээн дээр шидэв.

– Хамтдаа бодоод, юу хийж болохыг хэлцгээнэ үү.

Маргааш нь, зургадугаар сарын 28-нд Минск эзлэгдэв. Зургаан өдрийн дотор германууд зөвлөлтийн хэдэн арван дивизийг бут цохиж, долоон зуун тавин мянган улаан цэргийг олзолж, өчнөөн техник, зэр зэвсгийн агуулахыг булаан авчээ. Дайны анхны өдөр гэхэд л мянга хоёр зуун онгоц устгаснаас найман зуу нь хөөрч ч чадалгүй газар дээр ниргүүлжээ.

Энэ бол аргагүй сүйрэл. Гурав хоногийн дараа тэд нар Смоленскт ирэх нь, дахиад гурав хоногийн дараа Москвад...

Сталин ганцаараа өрөөндөө сууж байна. Дуугарах утас алга. Цөмөөрөө хаачсан улс вэ? Энд, ширээний ард доёилцоод л, элдвийг хөөрөн, идэж ууцгаагаад л байсан чинь гэнэтхэн ууршицгаачихаж. Турсгаа яаж аврах тухай бодоцгоож байх нь! Ялагдлыг өөр рүү нь тохох гэж хуйвалдацгааж байна, өөрийг нь золигт гаргах нь! Хүний адагнууд! Бузар шаарнууд! Тэд өөрсдөө хаа байсан болж байна? Германууд довтлохгүй гэж Молотов нотлоод байсан, Гитлер,

Геринг, Риббентроп энэ тэртэй уулзсанаа гоёчилж яриад байсан... Гадаад хэргийн ардын комиссар гээд байгаа шүү! Бас энэ маршал, генералууд? Өөрсдийнхөө зөв гэдгийг яагаад нотлохгүй, яагаад тэгж зүтгэхгүй байв? Мэхэлцгээж, нүд хуурч, төөрөгдөлд оруулцгаагаад, батлан хамгаалах талаар зохих арга хэмжээ авсангүй. тэрээр болгоомжтой байхыг шаардаж байсан нь үнэн, гэхдээ болгоомжлол гэдэг бол зүгээр суухын нэр биш. Одоо хүрч ирцгээнэ, элдэв гомдол саналаа дэлгэнэ, баривчлана, Москвагийн гудамжаар чаргуулдан чирнэ, улангассан бөөн хүмүүст өгч тасар татуулна. Энэ оготны хавхнаас бушуухан зайлах минь.

Сталин хонхоо дарав. Хүлээсэнэ лээ. Хэн ч орж ирсэнгүй. Поскребышев хүртэл зугтчихлаа гэж үү?

Сталин үүд рүү очиж, чимээ чагнав. Ямар ч анир алга. Поскребышев зугтчихаж! Үүднийхээ өрөө рүү шагайлаа. Хоосон байна. Тэгнэ ээ тэр, оргочихож, бузар солиг! Дараачийн хаалга руу өлмий дээрээ явж очоод, дахиад чагнавал гудаанд авиа ч алга. Хаалганы бариулаас дөнгөж бариад, дарж амжаагүй байтал хаалга гэнэт онгойв. Сталин ухар тусав. Өмнө нь баахан цаас барьсан Поскребышев өөр рүү нь гайхан хараад зогсож байв.

– Машин дууд! Зуслан явна! гэж Сталин сөөнгөтөн өгүүлэв.

Хэдэн машин шөнийн Москвагаар хурдлан давхилаа. Сталин арын суудлаас жолооч, хамгаалагч хоёрын араас харан, френчнийхээ халаасанд байгаа гар бууг базаж явав. Цонхны хөшгийг захаас нь жаахан ярсан боловч Москвагийн гэрлийг бүдгэрүүлсэн учраас цонхны цаанаас харагдах юм юу ч алга.

Хашааны хаалга нээгдэж, машин байр руу очиход, хамгаалагч хаалгыг нь нээж өгөв. Тэр хавьд нэг ч гэрэл алга. Сталин өрөө рүүгээ түргэн очиж, гэрлээ асаав. Өрөөнд нь салхи оруулсан учир амьсгалах агаар байна.

Оройн хоолонд юу авахыг мэдэхээр Валечка орж ирэв.

– Оройн хоол дараа больё, Власикийг ороод ир гэж хэл.

Тэгээд буйдан сандал руу лагхийн сууж, нүдээ анив.

Үнэхээр бүх юм баларлаа гэж үү? Аугаа их хүмүүс амжилтын хяр дээр, алдрынхаа оргил дээр амьдралаа дуусгадаг байсан, тийм учраас тэд үхэшгүй мөнх байгаа. Наполеон Европыг сөгдүүлснийхээ дараа ялагдал хүлээсэн, тэгээд хүн төрөлхтний ой тойнд агуу их жанжин болж үлдсэн. Робеспьер, өчүүхэн өмгөөлөгч, заяа муутай алан хядагч, оньст заазуураар толгойгоо авахуулсан. ӨӨРИЙГ нь үнэхээр ийм гутамшигтай төгсгөл хүлээж байна гэж үү?! “Журмын нөхөд” нь дайны ялагдлыг өөр рүү нь чихнэ, гүжирдэн гүтгэнэ, шившиг болгоно, ард түмний уур хилэн гэж зохиомол юм гаргана, бөөн хүмүүсийг турхиран тасар татуулна.

Ард нь юм шужигнав.

Айгаад эргэж харвал үүдэнд нь Власик зогсож байв.

– Чи юу гээд... икээ тэгмэр чинь, оготно шиг гэтээд байгаа юм гэж Сталин шазуур зуун шивнэв.

– Та дуудсан уу, нөхөр Сталин? хэмээн Власик самгардан бувтнав.

– Хэнийг ч битгий хүлээж ав, утсаар хэнтэй ч бүү яриул! гэж Сталин тушаав.

– Мэдлээ, гүйцэтгэе!

– Яв!

Сталин нүдээ дахин анихад, нэг зүүрмэглэж, нэг сэрж байх шиг санагдана. Яагаад, яаж байгаад ийм юм болов? тэрээр олон зууны настай, сүйршгүй улсыг байгуулсан, оршин тогтноход нь, бас ирээдүйд нь саад болж мэдэх бүх юмыг устгасан, үндсээр нь товрог болтол нь хуйхалсан, тэр ч бүү хэл, өөрөөр сэтгэх чадварыг хүртэл хүйс тэмтэрсэн. Хүүхэд ахуйгаас нь өөрийнх нь сургаж заншааснаас өөр ямар ч үзэл санааг мэдэхгүй, мэдэхийг ч хүсэхгүй шинэ үеийнхэн өсч бойжлоо. Энэ үеийнхний хувьд бол зөвлөлт улс хамгийн сайн, хамгийн

шудрага, өвтэгш улс, үлдсэн бусад нь бүгдээрээ шудрага бус, дайсагнасан улсууд, энэ үеийнхэн зөвлөлтийнхөөс өөр ямар ч аж төрөх ёсыг мэдэхийг хүсэхгүй байгаа. Таван сая герман цэрэг хоёр зуун сая тийм хүмүүсийг үнэхээр сөгдүүлж чадна гэж үү?!

Жолоодогчоосоо айх, түүнийг ухаангүй хайрлах, түүнд үг дуугүй захирагдах ёсонд үндэслэсэн, урам зоригт суурилсан хүчирхэг эзэнт гүрэн үнэхээр нурж сүйрнэ гэж үү? Ямар ч байдаг бай, Гитлер цөцгийн тос руу орж байгаа хутга шиг улс орон руу шааж орж ирээд, зургаа хоногийн дотор Минск хүрч, цааш урагшлан давшиж байна, цэргүүд нь бууж өгч олзлогдон, дарга нар нь юу ч хийхгүй байна.

тэрээр байрных нь гудаанд пир пархийсэн хөлийн чимээ гарахыг сонсов... Ирцгээв үү?! Хуйвалдагчид ирцгээж байна! түүнийг баривчлана, эсвэл Нэгдүгээр Павел шиг багалзуурдаад цааш нь харуулчихна.

Сталин сандлаасаа босон харайв.

Хаалга нээгдлээ. Үүдэнд зогсож байгаа Власик гараа өргөн ёслож,

– Илтгэхийг зөвшөөрнө үү? гэв.

Сталин түүн рүү хулмалзан харав. түүний ард хэн байна?! Власикийн ард хэн ч байсангүй.

– Чи юу гээд... икээ тэгмэр чинь, заан шиг дэвсчээд байгаа юм?!

– Илтгэхийг зөвшөөрнө үү, нөхөр Сталин. Армийн генерал нөхөр Жуков утасдаж байна.

– Хэнтэй ч битгий яриул гэж хэлсэн биз дээ!

– Мэдлээ, нөхөр Сталин!

Власик цэрэг ёсоор топхийн эргээд, гарлаа.

Жуков утасдаж... түүнд, энэ Жуковт юу хэрэгтэй юм бол? Германууд Смоленскийг эзлээд, одоо Москвагийн хаяанд ирчихээд байна гэж мэдээлэх гээ юү?! Жанжин штабын молхи дарга! мань ХҮН, түүний хамгаалалтынхан эцсээ хүртэл үзэлцэнэ, сүүлчийнхээ сумыг өөртөө зориулна. Бөөгнөрсөн амьтдаар тасар татуулснаас дээр. Берияд баригдаж, түүний Лубянскийн газар давхарт орж таарвал бүр долоон дор юм болно. “Журмын нөхөд” нь гагцхүү турсагаа аврахын тулд Гитлертэй тохиролцож, Украин, Белорус, Балт орчмын улсууд, Кавказыг Бакугийн газрын тостой өгч чадна, тэгээд түүнийг ялагдсаны буруутан болгоно, Лубянскийн газар давхарт аваачаад, Зөвлөлт Холбоот Улсаас урван тэрсэлсэн гэж мэдүүлэг авах гэж тэндхийн яс үйрүүлдэг яргачид эрүүдэн тарчлаана. Берия нүд ирмэхийн зуур уравчихна, муу хөгшин өдөөн хатгагч!..

Эрүүдэнэ, тарчлаана гэж бодохоос золтой л огичихсонгүй. түүнийг чухамдаа жар гарчихсан өвгөн хүн гэдгийг ёстой тоохгүй. Өвгөн намайг зодсон гэж хэн нь гомдоллоод байлаа даа... Олон хүн гомдол мэдүүлж бичиж байсан, харин энэ үг л санаанд үлдэж... “Өвгөн намайг зодсон...” Ноднин буудан авсан ардын жүжигчин, найруулагч Мейерхольд тэгж бичсэн.

Сталин босч шүүгээ рүү очоод, шургуулганаас нь архивт өгдөггүй, заримдаа эргэж уншдаг байсан захидал бүхий хавтсаа гаргаж ирэв. Алах ял заагдсан хүмүүсийн бум буман захианаас энд арав хорьхон нь байгаа.

Бухарины буудуулахаасаа хэдхэн цагийн өмнө бичсэн “өршөөл гуйх нь” энд бий: “Миний сэтгэлд эсэргүүцлийн ганц ч үг байхгүй. Би гэмт хэргийнхээ төлөө арав дахин алуулах ёстой. Би өвдөг сөгдөн зогсож байна. Шинэ Бухаринд амьдарч явахыг зөвшөөрнө үү. Пролетарич удам сэтгэлийн тийм өршөөл зөвтөнө”. Ингэж л бичиж байж шүү дээ.

Ежов: “Хувь заяа маань тодорхой байна, мэдээж, миний амь насыг гэтэлгэхгүй... Ганц зүйл гуйя: намайг зовоож тарчлаалгүй, тайван буудаж хорооно уу... Би Сталин гэдэг нэрийг хэлсээр үхнэ, үүнийг түүнд уламжлаарай...”

Буудан алуулсан Улс төрийн товчооны бусад гишүүдийн захиа ч энд байв. тэрээр тэдгээр захиаг түүхэнд зориулан хадгалж байгаа. Цаазлуулагсад буруутай байсныг мэдэж авцгааг, үүнийг тэд нар үхэхийнхээ өмнө бичсэн, тэгвэл үхэхийн өмнө худлаа хэлдэггүй.

Мейерхольд захиагаа түүнд бус, Молотовын хаягаар бичсэн. Берия тийм захиаг Молотовт дамжуулснаа өөрт нь илтгэсэн, тэгээд мань хүн Молотовоос,

– Мейерхольд чамд захиа бичсэн үү? гэж асуусан.

– Бичсэн.

– Юу гэж бичиж байх юм?

Молотов хариуны оронд энэ захиаг түүнд өгсөн. Тэгээд энэ хавтсанд орчихсон хэрэг. Албаны цаастай энд авчраад тэр чигээрээ үлдсэн бил үү? Эсвэл “Өвгөн намайг зодсон” гэдэг нь толгойд хоцроо юу?..

Сталин Мейерхольдын захиаг хавтаснаас гаргаж ирж уншив:

“Жаран настай, бие муутай өвгөн намайг энд зодсон, нүүрээр минь шал руу дарж хэвтүүлж байгаад, эрзээнэн сураар ул тавхай, ууц нуруу, хөл гуягүй ороолгож байсан... Тэгсэн газраар нь бөөн хөх няц болчихно, тэгтэл тэр хөх няцаар чинь нөгөө сураараа дахин ороолгоход арьс хөрсгүй бие рүү буцламгай ус асгаж байгаа мэт тэсэхүйеэ бэрх өвдөнө... Тэр сураар нүүр нүдгүй ороолгоно... Би өвдсөндөө бархирна, уйлна... Би шалан дээр түрүүлгээ хараад хэвтэж байхдаа, эзэндээ гүвшүүлж байгаа нохой шиг атиралдан мурчиганаж, гинах чадвартай байгаагаа мэдсэн удаатай...”

Сталин дахиад золтой огичихсонгүй. Өөрийгөө заяа нь ингүүлэхгүй, хол хэвтэнэ. Өөрийг нь энд германууд алаг. Ингэхэд, германууд түүнийг яагаад алах билээ? Тэдэнд түүнийг алах ямар хэрэг байна? Буулгаж авсан орныхоо удирдагчдаас тэд хэнд гар хүрсэн билээ? Хэнд ч хүрээгүй.

Гол нь амь насаа хамгаалж, эсэн мэнд үлдэх хэрэгтэй. Тэгүүлэхгүй дээ, муусайн урвагчид,

тэрслэгчид! Өөрсдийнхөө бузар амь насыг л аварцгаана.

тэрээр хонхоо дарав. Гудаанд хөлийн чимээ гарлаа. Муу годил, одоо л нэг хүн шиг явж байна. Власик орж ирээд үүдэнд хөшчихөв.

– Германууд манай руу шүхэрчид буулгаж байна хэмээн Сталин муухай царайлан өгүүлэв.

Власик нүдээ бүлтийлгэн чагнав.

– Шүхэрчид гэж Сталин давтан хэлээд, – Манай дүрэмт хувцастай, өөрсдийгөө ДЯАК-ын ажилтан гэцгээж байгаа, оросоор сайн ярина гэв.

тэрээр чимээгүй болзнож, Власик руу харахад, цаадах нь бүлтийсэн чигээрээ зогсох аж.

– Нам, засгийг толгойгүй болгохын тулд нааш нь хорлон сүйтгэх бүлэг илгээж мэднэ. Хамгаалалтыг чангатгах хэрэгтэй.

– Мэдлээ, нөхөр Сталин, одоо цэрэг дуудъя.

– Тэгж болохгүй! Хааш нь ч битгий утасд, хэнийг ч бүү дууд. Сонор сэрэмжээ л дээшлүүлэх хэрэгтэй. Нааш нь хэнийг ч нэвтрүүлэхгүйн тулд. Ойлгов уу?

– Ойлголоо, нөхөр Сталин, ёсоор болгоё.

– Яв.

тэрээр дахин сандалдаа сууж, дахин зүүрмэглэтэл, дахиад шужигнах чимээ сэрээчихэв. Гэхдээ тэр нь танил чимээ, Валечка оройн хоол авчирч байгаа нь тэр. мань хүн юмхан зажилмар болсон ч хоол идэх дур алга.

тэрээр сандал дээрээ дахин зүүрмэглэв, уул нь хэвтвэл зүгээр сэн, гэвч хувцсаа тайлахаас айгаад байж. Зөвхөн гутлаа тайлав.

Тийнхүү зүүрмэглэх, сэрэх ээлжлэн, шөнөжин сууж хонов. Бодол санаа нь будилан, нэг орж ирж, нэг мартагдана. Гагцхүү ганцхан юм л тодорхой байв: хоёр зуун сая. Хоёр зуун сая. Хоёр зуун сая. Ийм юмыг гэтлэн давж үнэхээр болно гэж үү? Бүгдээрээ, толгой дараалан босох юм бол хэн түүнийг нэвгэлж чадах юм бэ? түүний тушаалаар үхэл рүү очиход бэлэн байгаа хүмүүсийн далай, хэн тэднийг сөхрүүлж чадах юм бэ?

Сэрээд цагаа харлаа. Арван хоёр хагас. Гэр ч, гадаа ч нөгөө л үүлгэртэм нам гүм байдал. Валечка өглөөний хоол авчирч өгөв. Дахиад бараг юм идсэнгүй, хураа гэж тушаагаад, сандалдаа шигдэн суулаа. Дахиад л айдас эзэмдээд ирэх нь тэр. Улс оронд нь юу болж байгаа талаар мэдэж байгаа юм алга, радиогоо асаасангүй, асаахын хэрэг юу билээ, тайтгарах юм юу ч сонсохгүй, бас бүх үнэнийг ч сонсохгүй юм чинь. Нэмэрт нь ерөөсөө юм сонсох хүсэл алга. Бас юуны ч тухай бодож чадахгүй байна, санаа болгон өр шоролж зовоохоос цаашгүй. Тархи өрөмдөөд байгаа ганц юм нь хоёр зуун сая, хоёр зуун сая! Ийм аврага юмаар Гитлер шургалж гарч чадахгүй. Гэвч түүнээс урван тэрсэлцгээсэн, тэгсэн, тэгсэн...

Орой болов. Хоолны өрөөний булангаас эхлэн бүрэнхий сууж байна, мань хүн дахиад зүүрмэглэв.

Гудаанд чимээ гарахыг гэнэт сонсоод сэхээ орлоо.

Ирцгээж байна!

Гар буугаа авахаар босон харайх гэж үзэв. Гэтэл өндийх тамир алга. Нүдээ анилаа. Нүдээ нээтэл өмнө нь Молотов, Ворошилов, Маленков, Берия, Микоян, Вознесенский нар зогсож байв...

– Яах гэж... Яах гэж ирцгээв? гэж Сталин арайхийн асуув.

– Коба хэмээн Молотов эхлэв. – Хөдлөх хэрэгтэй байна. Улс орноо хөл дээр нь босгох хэрэгтэй, Улсыг батлан хамгаалах хороо гэж хүчирхэг төв байгуулж, түүнд бүх эрх мэдлийг шилжүүлж, засгийн газар, Дээд Зөвлөл, намын Төв Хорооны чиг үүргийг тэр хороонд өгье. Улсыг батлан хамгаалах хороог чи, Коба, тэргүүлэх ёстой, чиний нэр ард түмэнд итгэл, хүч өгч, цэргийн үйл ажиллагааг удирдах боломжийг хангана.

Сталин чимээгүй сонслоо. Ухамсар нь зугуухан сэргэж байна. Эдгээр хүмүүс түүнгүйгээр юу ч хийж чадахгүй юм, эрх мэдлийг гартаа авахаас айж байна, олигтойхон урван тэрсэлж ч чадахгүй шүү. Эд нар урьдын адил түүнд, гагцхүү түүнд сөгдөж байна, бас ард түмэн зөвхөн түүнд сөгдөж байна. түүнийг харж, түүний үгийг хүлээж байна. Гэхдээ мань хүн,

– За тэгье гэхээс цааш юм хэлж чадсангүй.

Одоо мань хүн тэднийг харж байв. Тийм ээ, эд нар түүнд сөгдөж байна, бас ард түмэн түүнд сөгдөж байна. түүнд сөгдсөн хоёр зуун сая хүн. Минскээс Москва хүртэлх бүх замыг энэ сая сая хүний биеэр чигжинэ, германы танк хүүрэн овоог давж гарч чадахгүй, германууд энэ өмхий бээнд бүтэж үхнэ, оволзсон түймрийн гал утаанд бахардаж үхнэ. Парисыг нээлттэй хот гэж зарласан, Гитлер Оросоос нээлттэй хот олохгүй, бүгдийг, хот тосгон, гацаа суурин, тариа будаа, үйлдвэр завод гээд бүгдийг галдан шатаана, эвдэлж сүйтгэнэ, устгаж үгүй хийнэ, германууд Украины тариа, Донецкийн нүүрсийг олж долоохгүй, гагцхүү цус, цус олж долооно, Гитлер тэр цусандаа цацаж үхнэ. Энэ бол сая сая хүний, живаа живаа хүний цус байх болно. Ингэхэд зүгээр, түүх үүнийг Сталинд өршөөнө. Харин тэрээр дайнд ялагдах юм бол, Гитлерийн эрхшээлд Оросыг өгөх юм бол үүнийг түүх түүнд хэзээ ч өршөөхгүй.

Берия эхэлж ам нээв.

– Улсыг батлан хамгаалах хороо цөөвтөр бүрэлдэхүүнтэй байх ёстой гэж бодож байна. Нөхөр Сталин тэргүүлнэ, гишүүд нь Молотов, Ворошилов, Маленков, Берия нар.

– За болох юм гэснээ, Сталин итгэл муутайхан, – Микоян, Вознесенскийн хоёрыг оруулах юм болов уу? гэж нэмж хэлэхэд Берия,

– Тэгвэл Совнарком, Төлөвлөгөөний комисс хоёрт хэн ажиллах вэ? Нөхөр Микоян, нөхөр

Вознесенский нар засгийн газрын ажлыг хийж байг л дээ хэмээн татгалзав.

Вознесенский,

– УБХХ долоон хүний бүрэлдэхүүнтэй байх ёстой гэж би бодож байна. Нөхөр Сталины нэрлэсэн хүмүүс УБХХ-ны бүрэлдэхүүнд орох ёстой гэж үзэж байна гэж итгэлтэй хэлэв.

Юунаас болоод ингэж зөрцгөөгөөд байна? Эд нар юугаа хувааж авч чадахгүй байна? Залины хөрөнгө Микоян,

– Бид цаг алдаж байна гэж санагдах юм хэмээн халаглав. – Маргалдах цаг биш гэж үзэж байна. УБХХ таван хүнтэй л байг л дээ. Би ч гэсэн, Вознесенский ч гэсэн тэртэй тэргүй чамгүй үүрэгтэй.

Эд нар нэгдмэл биш, хуучин янзаараа салангад сарниун байна. Энэ бол сайн хэрэг.

Сталин гутлаа өмсөж босоод, сэхээвч рүү очиж цэцэглэж байгаа зуны цэцэрлэг рүү харж хэсэг зогссоноо, эргэж харалгүй,

– За яахав, энэ нь ухаалаг болох байх, тэгж байгаад харъя. УБХХ байгуулах тухай зарлиг бэлдэцгээ. Маргааш хэдэн билээ? Долдугаар сарын нэгэн. Маргааш л нийтэлчих гэв.

тэрээр ард түмэнд юу хэлэх ёстойгоо одоо мэдэж байна.

– УБХХ байгуулсны дараа түүний дарга үг хэлэхийг ард түмэн хүлээх болно гэх Молотовын дуу ард нь гарав.

– Би долдугаар сарын гурванд радиогоор үг хэлнэ гэж Сталин хариулав.

Сталин үг хэлэхдээ ямар ч байсан мэгдэсхийн, хоолой нь цахиртан, ус балгаж байгаа учир, улс орны бүх радио цэг, цагаан хоолойгоор шилэн аяга галуун хзүүт шилтэй хавиран тожигнож буй дуу сонсдож байв. тэрээр амьдралдаа анх удаа: “...Ах, эгч, дүү нар аа... Би, анд нөхөд та бүхэндээ хандаж байна...” гэсэн үгийг хэллээ.

тэрээр, бүтэлгүйтэж буйн шалтгаан нь гэнэт довтолсон явдал мэтээр, дайсны шилдэг дивизүүдийг буг цохьсон мэтээр мэдээж худлаа ярьж байна. Гэхдээ гол нь энэ биш. Гол юм нь хүйс тэмтрэн сөнөөх дайн, бүрэлгэн сүйтгэх дайн зарласан явдал...

“Манай орон үхэх сэхэхээ үзэх дайнд орлоо... Бид ар талд элдвээр үймүүлэгчид, оргон зайлагчид, бажгадан уймрагчид, цуурхал тараагчидтай хайр найргүй тэмцэх ёстой, тагнуул, хорлон сүйтгэгчид, дайсны шүхэрчдийг хайр найргүй устгах ёстой... Дайсанд ганц килограмм ч талх үлдээх ёсгүй... Ганц литр ч шатахуун үлдээх ёсгүй... Хамаг мал сүргээ тууж явуулах хэрэгтэй... Дайсан ачаад явчихаж болох бүх юмыг заавал устгах ёстой... Зам, гүүр, шуудан, холбооны утас энэ тэрийг дэлбэлэх, ой мод, агуулах, ачаа хөсгийг шатаах партизаны отряд, хорлон сүйтгэх бүлэг зохион байгуулах ёстой... Дайсанд тэсвэрлэшгүй нөхцөл бүрдүүлж, тэднийг алхам тутамдаа алж устгаж байх хэрэгтэй... Бидний ялалтын төлөө урагшаа...”

Хэрэв тэрээр амь эрсдэх тавилантай бол, тэрээр ганцаараа эрсдэхгүй. Бүх ард түмэн ТҮҮНТЭЙ хамт эрсдэнэ. Нэг ч хүн үлдэхгүй.

Сашаг Рязань мужийн урд хэсэгт орших Пронск гэдэг жижигхэн хотод байхад дайн эхлэв. Шинэ засмал тавих геодезийн явуулын ангид жолооч хийж байж. Ням гаригийн өглөө хотын оршин суугчид төв талбайн цагаан хоолой руу шаван ирцгээв. Тэр болгон айлд радио байхгүй, радиотой зарим нь ч гэртээ сууж сонссоноос талбай дээр, олон түмэнтэй хамт байвал илүү юм сонсоно гэж найджээ. Молотовын хэлсэн үгийг чимээгүй сонсоод, чимээгүй тарцгаав. Дэлгүүрийн бүх давс, шүдэнз, саванг тэр өдөртөө хуу худалдан авцгаажээ.

Маргааш нь өдөр нь Пронскийн гудамжаар цэрэгт нас тэнцсэн, хотын болон хавь ойрын тосгон суурины энгийн хувцастай, мөрөн дээгүүрээ үүргэвч тохсон хөвүүд, залуу эрс жагсаалаар алхлан, хажуугаар нь тэдний ээж, эхнэр, сүйт бүсгүйчүүд ярих нь ярьж, хашгаралдах нь хашгаралдан явцгаалаа.

Саша явуулын ангийн ажилтан нарыг тэдний багаж сэлт, юм хумтай цуглуулах ажлаар “ГАЗ-АА” машинаараа барих замын дагууд жаал явав. Олон тосгон гацаанд хөвүүдээ дайнд мордуулж, бөөн орилоон шуугиан болж байлаа. Орон нутгийн дарга нар хурал цуглаан зохион байгуулан, дайчилгааг “соёлт төрхтэй” болгох гэж оролдсон боловч тосгоныхон тэднийг эрний заншлаар, орос ёсоор уйлаан майлаантай, дуу бүжигтэй, архи дарстай, элбэг дэлбэг хоол ундтай үдлээ.

Саша хайгуулын ээлжит ангийнхантай Пронск руу буцахаар, юм хумаа эмхлэхэд нь тусалж өнжив.

Өрөөнд нь радио өдөржин залгаатай байж. Фронтын мэдээнд тэгтлээ нэг их итгэхгүй. “Брестийн чиглэлээр маш ширүүн тулалдаан болж байна” гэж байвал тэр нь Брестийг дайсан эзэлсэн гэсэн үг. “Дайсан манай цэргийн ангиудыг шахаж дөнгөв” гэж байвал тэр нь манайхан ухарч байгаа буюу бүслэгдсэн, эсвэл устгуулсан гэсэн үг. “Нэг хоногийн дотор германы таван мянган цэрэг, офицерыг олзлон авлаа” гэх, гэтэл Минскийн хавьд тулалдаж байгаа бол хаанаас тэгж олзолсон болж байна?! Энэ бол манайхан германыг биш, германууд манайхныг олзолж байгаа хэрэг.

Рязаньд гэрэлтүүлгийг бүдгэрүүлж, цонхонд хөх цаасан хөшиг өлгөж, хашаа хороон дотор хоргодох шуудуу ухаж, гудамжаар цэрэгт тэнцэгчид жагсаалаар алхаж, Пронскт болсон шиг хажуугаар нь эхчүүд, эхнэрүүд, эгч дүүс нь гүйлдэж, цэргийн хэлтэс, цагдаагийн тасаг, сургууль энэ тэр дээр сайн дурынхан жагсаалын сургууль хийж байна. Саша ээж рүүгээ утасдаж, өөрийг нь мөд цэрэгт татна гэдгийг урьдчилан мэдэгдэв. Ээж нь дайны хамт Сашагийн хувьд шинэ амьдрал эхэлж байна, нөгөө онцгой юм нь ингээд улирч байна гэдгийг ойлгон, тайван ярьж байв.

Саша Рязаньд нөхөрсөг харилцаатай байсан цорын ганц хүн болох Евгений Юрьевичийнхээр оров. Арбатын ах шигээ зөөлөн сэтгэлтэй, соёлтой, бас ах шигээ хавчдаг шилтэй, шингэн халиун үстэй. Хөгжим сонсох дуртай, оройн цагаар том хүлээн авагчаас салахгүй сууна, одоо түүнийг арга буюу хураалгасан учир радио цэгээр өөрийгөө болгож байгаа аж.

– За ингээд, Саша, байлдах болж байх шив?! Би ардын журамт цэрэгт элсэх гэсэн чинь

авсангүй гээд Евгений Юрьевич шил рүүгээ заав. – Ажил дээрээ ч, гэртээ ч шуудуу ухаж байна. Энэ шуудуу бөмбөгдөхийн үед тус болох болов уу, та юу гэж бодож байна?

– Тус болох байлгүй.

– Би ард олны нэгдэн нягтарч байгааг гайхшрахын хамт бас тайтгарч байна. Шудрага бусаар үй олон амьтан зовсон, гэтэл аюул нүүрлээд ирэхээр гомдлоо мартаж байна. Манай ар тал руу германууд тагнуул, хорлон сүйтгэгчдийг хаяж байна гэж сонин хэвлэлээр бичиж байна, тэр бол гарцаагүй, гэхдээ Орост урвах шарвах юм гарахгүй. Нэг ч дайнд оросуудын дотроос урвагч гарч байгаагүй.

– Гитлер хамтралыг тарааж, тариачдыг чөлөөлвөл яахав?

– Гитлер хамтралыг сүйтгэвэл өөрт нь л тариа олдохгүй дээ. Газраа хувааж автал, төвхнөж гүйцтэл баахан цаг өнгөрнө. Гэтэл Гитлерт тариа одоо хэрэгтэй.

– Тэр чинь тэдэнд газар амлаж мэднэ.

– Ээ, Саша минь, хэрэв Ленин арван долоон онд газар, энх тайвныг зөвхөн амласан бол мань хүн засгийн эрхэнд долоо хоног ч тогтохгүй байсан. Тэр чинь энэ бүхнээ нэг өдөрт л өгсөн, ганцхан хууль гаргаад л, тийм учраас ялсан. Амлалтад хэн ч итгэхгүй. Саша минь, орос хүн булаан эзлэгчдийг тэвчихгүй, тийм шүү. Манай удирдагчид үүнийг үнэлэж, хүмүүст илүү итгэдэг болно гэж би бодож байна. Би бол, Саша, дайны дараа шинэ, сайн цаг ирнэ гэж найдаж байна.

Саша үүнийг сонсоод, одоо нийтээрээ ийм л эх оронч, дайчин санаа бодолтой байгаа, тэгэхээр өөрийнх нь хувьд ч гол юм нь эх орноо хамгаалах асуудал болж бусад бүх юм хойш тавигдаж байна.

– Цэргийн хэлтсээс зарлан дуудах хүлээж байна гэж Саша өгүүлээд, – Би танайд нэг их зай эзлэхээргүй юу хээхэн үлдээж болох уу? Ердөө ганц чемодан, боодолтой хэдэн ном гэв.

– Асуух юу байхав?! Тэгж үз! Буцаж ирэхээрээ л авна биз. Харин заавал ялж байж л буцаж ирээрэй!

– Хичээнэ ээ гээд Саша инээмсэглэв.

Саша цэргийн хэлтэс дээр паспорт, цэргийн батлахтайгаа ирэх дуудлага долоо хоногийн дараа авав. Ядарч, түүртсэн дэслэгч Сашагийн паспортыг авч хайрцагт хийгээд, цэргийн батлахыг нь үзсэнээ, бүртгэлийг нь хайж олов.

– Таны иргэний мэрэгжил юу билээ, жолооч уу?

– Жолооч.

– Жолоочийн үнэмлэх бий юү?

Саша түүн рүү үнэмлэхээ сарвайв.

Дэслэгч түүнийг нь зэрвэс хараад, гартаа ч барьж үзэлгүй, зарлан дуудахын маягтыг бөглөж Сашад өгөв:

– Ажлынхаа газарт үзүүлээд, тооцоо бодуулж, авах ёстой бүх юмаа аваарай, тэгээд маргааш... “Сельмаш” үйлдвэрийг мэдэх үү?

– Мэднэ.

– Тэгвэл тийшээ өглөө найм гэхэд очоорой.

“Сельмаш” үйлдвэр дээр автын батальон бүрдүүлж байв. Штабын дарга Сашагийн үнэмлэхийг дэлгэж үзээд, шагшин толгой сэгсрэв.

– Арван нэгэн жил жолооч хийж. Боловсрол юу билээ?

Сашагийн халаасанд нөгөө сургуулиасаа авсан гэрчилгээ нь байж, тэгээд мань хүн,

– Төгсгөөгүй дээд гэж хариулав.

– Хаана сурч байсан билээ?

– Тээврийн дээдэд.

– Батальоны дарга дээр очъё.

Батальоны дарга Юлдашев гэдэг намхан туранхай татар нүдээ онилгон Сашаг ажиглав.

– Сургуулиа яагаад төгсөөгүй юм?

– Ар гэрийн гачигдлаар.

– Хэддүгээр дамжаанаас гарсан юм?

– Дөрөвдүгээр дамжаанаас.

– Машин хүлээн авч байна, мэрэгжилтэн, мэдлэгтэй хүмүүс шаардлагатай байна. Техник ангийн туслах, нэгдүгээр зэргийн цэргийн техникч Коробковын мэдэлд түр очиж бай.

Саша халуун усанд орж, хувцсаа ариутгах шүүгээгээр оруулаад, цэргийн хувцас хараахан ирээгүй байгаа учир агуулахаас ажлын хувцас авав. Бас эндээ, заводын гуанзанд хооллож байх тасалбар тавьж өгч. Нийтийн байр гэж баахан нүцгэн банзтай төмөр ор тавьсан цех юм уу, агуулахын байр. Гудас, дэр, цагаан даавуу энэ тэр алга.

– Дуртайгаа шилээд ав, машинаа авчихсан нь бүхээгтээ унтдаг юм, энд бол чөлөөтэй шүү. Юм хум байгаа бол цэргийн агуулахад өгчих, арай бүрэн бүтэн үлдэнэ гэж жижүүрийн цэрэг

зааварлав.

Машиныг хашаан дотор хүлээн авч байв.

Паравгар уруултай Коробков гэдэг савхин гутал, ажлын хувцастай болхи эр Сашаг тээврийн дээдэд сурч байсныг дуулмагц малилзаад явчихав.

– Хөөе, чи бид хоёр чинь нэг ангийнхан юм байна шүү дээ!

Үгүй ээ ер, нэг ангийнхан. Сашад энэ л дутаж гэнэ дээ! Гэхдээ мань хүн ямар нэг Коробковыг санахгүй байж. Энэ ч ямар хамаа байхав. Хуучин амьдрал дуусч, шинэ амьдрал эхэлсэн.

– Манай салбарт МАДИ (Москвагийн автозамын дээд сургууль) гэж нэр өгөөд Ленинградын өргөн чөлөө рүү нүүлгэчихсэн, би энд ганцаараа аргацааж байна, манай батальоны дарга чинь хуучин морин цэргийн хүн, тийм учраас хамаг техник над дээр, ойлгож байгаа биз дээ. Харин нэг туршлагатай механик тусалж байгаа.

тэрээр машины дэргэд зогсож байсан, хуучирсан пиджагтай ахимаг хүнийг,

– Василий Акимович! хэмээн дуудав.

Цаадах нь гараа даавуугаар арчсаар хүрч ирэв.

– Танилц, байлдагч Панкратов, машин хүлээж авах хүн.

– Хүлээж авч л бай л даа!

Василий Акимович Сашаг хайрамжгүй зэрвэсхэн хараад, машинууд руугаа эргэж очив.

– За хө, цаг алдаад яахав гээд Коробков хүлээж байгаа машинуудыг өнгөрч, шинэхэн будаг нь гялалзсан хоёр “пулуу” руу очиж, – За энэ хоёроос эхэл гэв.

Машины хавьд сайхан хромон гуталтай, суран мөрөвчтэй дарга цамцтай малигар залуу зогсож байна. Одоо хариуцлагатай ажилтнууд ийм өмсгөлтэй байдаг, гэхдээ ташаан дээрээ бэржээхэн цүнхтэй байгааг үзээд Саша түүнийг хангамжийн хүн гэж тодорхойлов.

– За яав, “Хотын худалдаа” гуай, будаг олсон уу? хэмээн Коробков түүн рүү дохив.

– Тушаалын дагуу бүх юмыг ёсоор болголоо, нөхөр нэгдүгээр зэргийн цэргийн техникч ээ хэмээн хангамжийн нөхөр сэргэлэн илтгэв.

– Би энэ хоёр машиныг өчигдөр үзсэн юм, дажгүй машин, гэхдээ үзэмж гэж авах юм байхгүй, тэгээд шинээр буд гэсэн чинь будаг байхгүй гэж тайлбар тавиад байсан юм. Тэгтэл олсон байна, тийм үү?

– Эх орон шаардаж байхад улс өгөх ёстой хэмээн цаадах нь жуумалзав.

– За яахав, Панкратов, ажлаа явуул, би явлаа гээд Коробков буцав.

Саша жолоочид мотороо асааж, нээлхийгээ онгойлгохыг тушаав. Тэгээд янз бүрийн хурд дээр тавьж моторыг нь чагнаад, унтраа! гэж жолооч руу дохив.

– Хүлээж авахгүй боломжгүй байна, мотор нь цохьчихож гэж Саша нээлхийг буулгангаа хэлэв.

Саша хоёрдугаар машиныг жолоо нь холхиж байна, урд бие суларсан байна гээд бас голлоо.

– Өөчилж байх шив, дарга аа гэж хангамжийн нөхөр үрчийн хэлээд штаб руу зүглэхийг үзвэл, Коробковт гомдол мэдүүлэхээр явж байгаа бололтой.

Саша тэр өдөр эвдрэлтэй, дугуй нь халзан, будаагүй, аккумулятор нь суусан гэх мэтийн шалтгаанаар нэг ч машин хүлээж авсангүй.

Яршигтай ажил! Тушаах хүмүүсийн зарим нь ичгүүргүй зан гаргана, зарим нь долигононо, зарим нь царайчлан харна. Саша эднийг өрөвдөнө, засах боломж байхгүйг нь ойлгож байгаа, машин тушаагаагүйгээс болж шүүхэд ч очиж мэднэ, гэвч шаардлага хангахгүй машин фронтод зориулан хүлээн авах эрх түүнд байхгүй.

Коробков мэл гайхчихав.

– Нэг ч бүтэн машин алга гэж үү? Чи дэндүү өндөр шаардлага тавиад байгаа юм уу? Уг нь тэр машинуудыг чинь би үзсэн юм шүү дээ.

– Тэгвэл хамтдаа үзэж болно гэж Саша өчив.

Гэвч Коробковт хамтдаа үзэх хүсэл байсангүй,

– Байдал ноцтой байгаа, хугацаа маш шахуу. Бидэнд шинэ машин хэн ч өгөхгүй. Хэрэв машин техникийн үзлэгт орсон, тэгээд одоо явж байгаа бол хүлээж авах хэрэгтэй гэж үзэж байна гэж санаа зовнингуй хэлэв.

– Би тийм дүгнэлтэд гарын үсэг зурахгүй гэж Саша хариулав.

Коробков хөмсөг зангидан,

– За яахав, одоохондоо зугаалж бай гэв.

Юун “зугаалах” байх вэ дээ: жагсаалын сургууль, дүрэм, винтов, гранат, жагсаалаар явах болон байлдааны нөхцөлд хөдөлгөөнд орох журам, бөмбөгдөх, их буугаар буудахад баримтлах дэг, шатаж эхэлсэн машиныг унтраах... энэ тэр гээд үй олон юм заана. Хичээлийг тун сая авто сургууль төгссөн Корнюшин, Овсянников гэдэг хоёр залуухан бага тушаалын цэргийн техникчид заана.

Жолооч нар хараал зүхэл тавьж: тэгвэл өөрснөө суугаад, жолоодоод яв гэж дарга нартай

хэрэлдэнэ. Тэд нар муу машин хүлээж авахгүй байгааг нь сайшаан Сашад сайн. Заримдаа зөвөлгөө авна, Саша машиныг боломжийн мэдэх юм чинь.

Бас улс төрийн хичээл хийнэ, түүнийг улс төрийн удирдагч, бэлтгэл офицер Щербаков удирдана. “Правда”, “Красная звезда” сониныг уншицгаагаад, уншсан юмаа өөрсдийнхөө үгээр ярь гэж Щербаков тушаана. Хотын жолооч нар яаж ийгээд юмхан ярьдаг бол, хөдөөнийхөн чадахгүй. Щербаков бухимдан: “Маргааш гэхэд цээжил!” гээд байлдагчид сонин өгнө.

Саша, мэдээж, түгдрэхгүй хариулна. Щербаков үүнээс нь болгоомжлон, түүнийг хялайж харах янзтай байж.

Хоёр хоногийн дараа Сашаг батальоны дарга руу дуудав. Юлдашевын өрөөнд Коробков, механик Василий Акимович, цэргийн техникч Корнюшин, Овсянников хоёр, тэдгээрээс гадна шинээр ирсэн нэгдүгээр сумангийн дарга ахлах дэслэгч Березовский нар байв.

Байлдагч Панкратов таны тушаалаар ирлээ гэж Саша илтгэв.

Юлдашев сандал руу зааж, Саша суув.

түүний араас улс төрийн удирдагч Щербаков орж ирж, бүгд рүү нь тоомжиргүй дохиод, Юлдашевын дэргэд очиж суув.

– Материал хүлээн авч байгаа явцын талаар техникийн зөвөлгөөн хийе. Нөхөр Коробков та ярина уу.

Коробков илтгэв. Хуваарь ёсоор өдөрт хорин машин хүлээн авах товгой. Гэхдээ хуваариас хоцорч байгаа тал бий. түүнийг нөхөж гүйцээнэ.

– Асуулт тавьцгаах уу? гэж Юлдашев мэдэгдэв.

– Нөхөр ахмад, зөвшөөрнө үү? хэмээн Щербаков эхлэв. – Надад байлдагч Панкратовоос асуух юм байна. Байлдагч Панкратов!

Саша түүн рүү асуух мэт харав.

– Байлдагч Панкратов! хэмээн Щербаков давтав. – Танд дээгүүр цолтой хүн хандаж байхад босох хэрэгтэй.

Саша бослоо.

– Байлдагч Панкратов! Танд машин хүлээж авахыг даалгасан. Та бүгдийг нь голсон байна. Тэр машинууд явж байсан уу?

– Явж байсан, гэхдээ...

– А-хаан, явж байсан, яагаад хүлээж аваагүй юм! гэж Щербаков үгийг нь тасдав.

– Өрөөсөн хөлтэй, хиймэл хөлтэй, эсвэл таягтай хүн ч бас явж байгаа. Гэхдээ тэднийг цэрэгт авдаггүй.

Ахлах дэслэгч Березовский жумалзаад, Сашаг тогтосхийн харав.

– Та цэцэн үгээр гайхуулахгүй байвал зүгээр сэн! гэж Щербаков хорон өгүүлэв. – Та армид байгаагаа битгий мартаарай, бас наад сэхээтнийхээ элдэв араншинг орхивол таарна. Та жолооч нарт ямар үлгэр үзүүлж байна? Тэд машинаасаа татгалзаж, шинэ машин шаардаж байна.

Жолооч нар шинэ машин биш, гэмтэлгүй машин хүсч байгааг Саша мэдэж байсан ч,

– Би жирийн жолооч, техник хүлээж авах бол миний үүрэг биш гэж хариулав.

– Танд хүлээж авахыг даалгасан, тийм учраас та хүлээж авах үүрэгтэй.

Саша дуугарсангүй. Энэ мулгууд тэрээр юу хариулж чадах сан билээ?

– Панкратов, та суу гэснээ Юлдашев, – Таны хүлээж аваагүй машины согогийг засч болох уу? гэж асуув.

– Батальонд болохгүй, хэрэгтэй юм нь байхгүй. Гэхдээ Рязаньд автобаз, засварын газар, сэлбэг борлуулах газар энэ тэр бий, юу ч олоод хийчихэж болно.

Юлдашев механик Василий Акимовичид хандан,

– Таны бодол, нөхөр Синельщиков? гэв.

– Аж ахуйнууд согог, гэмтлээ засахыг хүсэх юм бол тэд чадна. Мэдээж, туслах хэрэгтэй, аанай л хотын намын хороогоор дамжуулж шүү дээ.

Ахлах дэслэгч Березовский,

– Би манай сумангийн хэдэн машиныг өнгөцхөн харсан. Машины байдал муу байна, аккумулятор нь сулхан, дугуй нь халзан гэж хэлэв.

Коробков ийн эсэргүүцэв:

– Нөхцөл байдлыг бодолцох хэрэгтэй, нөхөр ахлах дэслэгч. Машины үндсэн хэсгийг армид зургаа, долдугаар сард тушаасан. Бид үлдэгдлийг нь түүж байна.

– Ганцхан нөхцөл байдал байгаа, фронтод гэмтэл согоггүй машин хэрэгцээтэй, тэнд байлдах хэрэгтэй байгаа гэж Березовский тас дайрав.

Штабын дарга орж ирж, өмнө нь нэг цаас тавьсанд Юлдашев түүнийг уншив:

– Цахилгаан ирсэн байна: техникийн тусламжийн машин авахаар Москвад яаралтай ир

гэжээ. Хэнийг явуулах вэ?

– Би яваад ирж болно гэж Коробков дор нь саналаа хэлэв.

– Батальон техникийн удирдлагагүй байж болохгүй гэснээ Юлдашевын харц Овсянников дээр тусч, – Нөхөр Овсянников, та жолооч аваад яв. Танай салаанд жолооч бий юү? гэв.

– Одоохондоо ганцхан байгаа, байлдагч Панкратов.

– Тэгвэл байлдагч Панкратов л тантай явна даа гээд тэрээр цахилгааныг штабын даргад эргүүлэн өгч, – Эдэнд бичиг баримтыг нь өгөөрэй гэв.

Саша босч:

– Нөхөр ахмад, илтгэхийг зөвшөөрнө үү, би дүрэмт хувцас аваагүй гэв.

– Тавьж өгөх шийдвэр өг гэж Юлдашев тушаав.

– “Бэу” (“хэрэглэж байсан”, орч.) гэж штабын дарга асуух, хэлэхийн завсар өгүүлэв.

– Энзэ-гээс (халдашгүй нөөцөөс, орч) өг.

Тэгвэл шинэ хувцас байгаа гэсэн үг, цөөхөн учраас харамладаг хэрэг байх.

Ямар санаандгүй, ямар азтай хэрэг вэ! Юлдашев, мэдээж, чухамхүү өөрийг нь явуулах гэж л дээ. Зальтай татар. Ухаантай эр. Муу Щербаков годилыг сайхан нааж өглөө.

Саша Евгений Юрьевичээс ном, чемоданаа авч, өөртөө хоёр хос дотуур хувцас, ноосон оймс, ноосон цамц, хүзүүний ороолт, нүүр гарын алчуур, сахлын хутга, саван, шүдний сойз, үнэртэй ус, ээжийнхээ зураг, Чеховын хоёр боть энэ тэрээ ялгаж авав, бас өөрөө чирэх юм биш, машинд зай олдоно хэмээн “Дайн ба энх”-ийг авлаа. Бусад бүх юмаа чемодан, үүргэвч хоёртоо эмхэлж хийлээ. Орой нь ээждээ утасдаж, албан томиллолтоор очих гэж байгаагаа мэдэгдэв.

Цэргийн техникч, тэр хоёр өглөө эрт галт тэргэнд ороод суучихсан байлаа. Вагонд зорчигчид нэг их олонгүй байснаа, Москва хүрэхийн алдад бүр цөөрөв. Москва руу зөвхөн тусгай үнэмлэхээр буюу төвийн байгууллагын дуудлагаар яваа улсыг оруулна.

Овсянников нөхөрсөг, яриа хөөрөөтэй, эелдэгхэн залуу болж таарав. Саша захиргаанд нь байгаа хүн ч гэсэн түүнийг өөрөөс нь ахмад, нэмэрт нь “сэхээтнийх” нь хувьд “та” гэж харилцаж байв.

– Таныг таягтай тахир татуу хүний тухай хэлж, улс төрийн удирдагчийг мад тавихад би айхдаа золтой л сандал доогуур орчихоогүй хэмээн инээмсэглэв.

– Юунаас айх билээ?

– Улс төрийн бүрэлдэхүүнтэй хэрэг! Тэдэнд нэг үг буруу хэлчихлээ гэхэд дараа нь сайнаа үзэхгүй.

Овсянников Москвад ерөөсөө анх удаа ирж байгаа учир нүд нь орой дээрээ гарав. Галт тэрэгний буудал, талбай, олон хүн, трамвай, бөөн машин. Төөрчихнө гэж айгаад Сашагаас алхам ч холдохгүй. Эргүүлийн цэрэг тэр хоёрын бичиг баримтыг шалгахад хулчганан бүлтгэнэнэ.

Сашагийн нүдэнд бол гудамжны хүн цөөрч, мухлаг бараг байхгүй болсон нь тод тусчээ. Цэрэг цамцтай, савхин гуталтай хүүхэн олон байна, цэрэг ачсан машин олон явж байна, орой болохоор агаарт хөөргөх ёстой мөнгөлөг агаарын бөмбөлгүүд газарт зөндөөн байна, талбай дээр зенитийн буунууд суурилуулсан байна.

Тэдний техникийн тусламжийн машинаа авах бааз нь эндээс холгүй, Красносельскийн дүүрэгт байгаа. Хүнгүй шахуу трамвайгаар явж очоод, нөгөө баазаа нэг хөндлөн гудамнаас олов. Уг нь агуулахархуу юм байсан бололтой. Хөвөөлөөд баахан засварын газруудтай, саравчин доороо олон машинтай, төмөр замтай цэлийсэн том хашаа, штаб руу гудман талаасаа ордог аж. Гудаанд нь баахан цэргийн улс, жолооч нар, цэргийн техникчид, бас л машин авахаар яваа байх. Бичиг хэрэг дээр нь бичээч хүүхэн тэдний бичиг баримтыг нэг жагсаалттай тулгаж үзээд, Овсянниковт буцааж өгөв.

– Баазын дарга руу оч, зүүн гар тийшээ эргээд, гудааны эцэст, сүүлчийн хаалга.

Овсянниковыг дарга руу явахад, Саша чемодан дээрээ суугаад, энд хичнээн саатахыг бүү мэд, ээждээ утасддаг байж гэж амаа барив.

Овсянников гарч ирээд,

– Нөхөр Панкратов! Цуг орохоос. Таныг нэхээд байна! гэв.

Саша Овсянниковыг дагаад даргын өрөө рүү орлоо.

Ширээний ард гуравдугаар зэргийн цэргийн инженер сууж байв. Толгойгоо дээшлүүлэн Саша руу харав... Руночкин!.. Ээ, чөтгөр чамайг, нөгөө нэг дамжааных нь Руночкин, хялар нүдтэй, хазгардуу, давжаа Руночкин!

Руночкин Сашагаас хараа салгахгүй босов.

– Саша, энэ чинь чи юү?

– Бараг л мөн байх...

Руночкин ширээнийхээ араас гарч ирж, тэр хоёр тэврэлдэн үнсэлдэв.

тэрээр сэтгэл догдолсноо нууж, гүдэсхэн хээгүй янзаар,

– Яагаад зогсоод байна, сууцгаа! гэв.

мань хоёр суулаа.

Улирч одсон хараалт өдрүүдээс Сашад үлдсэн аятайхан дурсамж олон биш. Гэхдээ Руночкиныг нэхэн санахад таатай байв. Сургуулийн явдлаар өөрийг нь хаацайлж, өмөөрч байсан, түүнд тэрслээгүй цорын ганц үнэнч нөхөр. мань хүн сайхан хувилжээ. Цэргийн хувцастай болоод ч тэгж харагдсан байж магадгүй. Хазгар нь мэдэгдэхгүй, намхавтар, дажгүй дарга болсон байна, юун хялайх, цэв цэх харцтай, өөртөө итгэлтэй, тэр ч бүү хэл, захирангуй янзтай байна. Саша нэрийг нь мартчихсандаа сэтгэл зовов. Оюутнууд бие биеийгээ нэрээр нь нэрлэх нь ховор, голдуу овгоор нь дууддаг асан. Тэгээд л мартчихаж. Түүнтэй яаж харьцах вэ? Цолоор нь уу? Цаадах нь түүнийг байлдагч Панкратов гэхгүй, нэрээр нь нэрлэлээ шүү дээ.

– Нөхөр цэргийн техникч, танай дарга нар чамтай Панкратовыг явуулсандаа Бурханд баярлавал таарна гэж тэд нартаа хэлээрэй, бид хоёр дээд сургуульд хамт, нэг бүлэгт сурч байсан юм, ойлгов уу? Би та хоёрт нэг ч авто батальонд байхгүй техник өгнө. Ойлгов уу?

– Яг тийм, ойлголоо, нөхөр гуравдугаар зэргийн цэргийн инженер. Баярлалаа.

– Чи илүү үг битгий хэрэглэ... Зүгээр: цэргийн инженер гэж бай.

– Мэдлээ, нөхөр цэргийн инженер.

– Машинаа маргааш авна. Яг аравт энд байх хэрэгтэй. Нөхөр Панкратовын буух газар...

– Ээжийндээ гэж Саш хэлж өгөв.

– А-хаан, харин, нөхөр цэргийн техникч, танд бол нийтийн байранд унтах газар өгнө, хажууд кино, ойрхон Тээвэрчдийн театр байгаа, уйдаах явдал байхгүй.

Руночкин хонхны товчоо дарав. Нөгөө бичээч бүсгүй орж ирэв. Руночкин түүнд бичиг баримтыг өгч,

– Томилолтыг нь бөглөж, хүнс тавьж өг, байлдагч Панкратовг хуурай хүнс, тийм биз дээ Саша? гэв.

– Мэдээж.

– Харин цэргийн техникч бол манай гуанзанд орсон нь дээр гэж бодож байна. Ямар вэ, цэргийн техникч ээ? Нийтийн байранд май загас хэмлэх үү, эсвэл халуун хоол авах уу?

– Халуун хоолыг нь илүүд үзэж байна.

– Цэргийн техникчийг гуанзанд данслаад, нийтийн байранд томилолт бичиж, зургадугаар өрөөнд оруул.

– Дмитрий Платонович, хаминдаа зургадугаар өрөөнд таны зурвасаар оруулна гээд байдаг юм.

За яамай даа! Нээрэн Дима гэдэг шүү дээ, Дима, Димка.

Руночкин цаасан дээр нэг юм бичээд бичээчид өгөв.

– Цэргийн техникч, та яв, таны бүх юмыг зохицуулаад өгнө, Панкратовын бичиг баримтыг нааш нь аваад ир, Лариса. Ингээд явцгаа!

Овсянников босов.

– Мэдлээ, нөхөр цэргийн инженер.

– Алив, байзаарай! гэснээ Саша нэг юм цаасан дээр бичиж, – Энэ ээжийн маань утас, юмыг яаж мэдэхэв гээд Овсянниковт өгөв.

– Өө, юун сайн юм бэ. Би таныг гудаанд хүлээж байя, нөхөр Панкратов.

– Энийг хүлээх хэрэг юу байна? гэж Руночкин асуув.

– Би нөгөө юм хумыг л... хүн аваад явчих вий гэж...

– Юун юм хум?

– Би нэг чемодан, бас хэдэн номтой яваа, миний хогшил л доо, ээжийнд орхих гэж байгаа юм, гудаанд байгаа гэж Саша тайлбарлав.

Руночкин хаалга нээж, тэнд явж таарсан цэрэгт, чемодан энэ тэрийг өрөөндөө оруулахыг тушаав.

– Явж болох уу, нөхөр цэргийн инженер?

– Болно!

Овсянников ёслоод, топхийн эргэж гарав.

– Чиний энэ чинь дарга гэхээсээ илүү хиа цэрэг шиг юм гэж Руночкин өгүүлэв.

– Ёстой эелдэг залуу. Дима би утасдвал болох уу?

– Яриа юу байхав гээд Руночкин утсаа түүн рүү дөхүүлэв.

Саша ээж рүүгээ залгаж, Москвад ирчихсэн, мөд сулрана, тэгээд очно гэж хэлэв.

– Одоо хүртэл итгэж чадахгүй байна, Сашка, нээрэн шүү. Танай цэргийн техникч томилолтоо гаргаад өглөө, харсан чинь Панкратов, А. П. гэж байна, тухайлж анхаарсангүй, өчнөөн амьтан орж гарч байгаа юм чинь, тэгтэл нэг юм толгойд зурсхийгээд явчих шиг... Панкратов А. Александр биш байгаа? Гэнэт мөн байвал?! Тэр Панкратовоо дагуулаад ир гэлээ... Тэгээд чи одоо энд байж байна! Ингэж уулзана чинээ санасангүй, нээрэн шүү, чамайг алга болсон, манай Саша бусдын адил алга болсон л гэж бодож байлаа. Би ээж дээр чинь нэг очсон, чамайг Бутырькийн шоронд байгаа гэж хэлсэн, би дараа нь, сургууль төгсөөд хөдөө хөөгдсөн, тэгээд чиний ул мөрийг алдчихсан.

– Чамайг ирсэн гэж ээж намайг шоронд нэг эргэхдээ хэлсэн. Ээж дээр очсон хүн ганц чи. Чамд баярласан шүү.

Руночкин гараа хайш хаяж, буруу харснаа,

– За, Саша, тэр яахав... Өөрийнхөө тухай яриач гэв.

– Өөрийнхөө тухай юу? Юу ярих билээ? Сибирыг, Ангар дээр гурван жил цөллөгт өнгөрөөсөн. Дараа нь хар дансны хүн болсон, том хотуудад суух эрхгүй. Дайн л тус боллоо. Одоо бол би бусадтай адилхан цэрэг.

– Гэхдээ яагаад байлдагч байгаа билээ?

– Намайг баривчлаад, сургуулиа төгсгөх боломж өгөөгүй.

Руночкин толгой сэгсрэв.

– Увайгүй шаарнууд, юу гээчийг хийв дээ! Манай сургуулиас л гэхэд бараг талыг нь

шүүрдчихсэн.

– Би энэ талаар юу хээ мэднэ ээ...

– Тэгээд л Гитлер Смоленскт ирчихээд байна гэж Руночкин хорсолтой өгүүлэв. – Одоо энэ тухай ярихаа больё! Үгүйдээн чи амьд үлдсэн нь яамай! Гэхдээ байлдагч байхдаа яахав дээ?! Ерөөсөө ингэнэ ээ, би чамайг эндээ аваад ирье.

– Яаж тэр билээ?

– Маш амархан. Тийм нэг хүнийг манай мэдэлд нэн даруй томилон ирүүл гэсэн дуудлага Ерөнхий газраар дамжуулаад явуулчихна.

– Тэгээд би юу хийх болж байна?

– Юу хүссэнээ хий: бригадын ахлагч, цехийн дарга, бид одоо засварын галт тэрэг тоноглоно гээд тэрээр цонх руу заав. – Харж байгаа биз дээ, энд төмөр замын салаа байна. Цол олгоно, нэг хэсэгтээ Москвад суух болно, тэгж байтал дайн яаж өрнөхийг харан байж шийднэ.

– Баярлалаа, Дима, гэхдээ наадах чинь миний хийх ажил биш. Цол олгоно оо? Биеийн байцаал бөглөх, ял эдэлж явсанаа хэлэх хэрэгтэй болно.

– Сашка, чи юу яриад байна аа? Одоо чинь тэнэг хүн л биеийн байцаалд үнэнээ бичнэ. Хэн шалгах юм? Шалгадагууд чинь элдэв нүх сүвээр нуугдчихсан.

– Бас Москвад дэндүү олон танил бий. Эргэж хургаж явмааргүй байна. Дөрвөн жил тэгж явлаа. Залхаж гүйцлээ! Одоо болоо! Дайн, фронт, ямар ч асуулт байхгүй!

– Мулгуу дарга дээр үү? Танай батальоны дарга чинь хэн бэ?

– Ахмад Юлдашев.

– Тийм овог сонсоогүй юм байна. Техникийн туслах нь?

– Коробков, хоёрдугаар зэргийн цэргийн техникч.

– Коробков оо? Венька юу?

– Би нэрийг нь мэдэхгүй.

– Тэгвэл би мэдэж байна. Нэгдүгээр зэргийн цэргийн хулчгар. Танилын татаасаар явдаг хүн, дээд сургууль төгсөөд ардын комиссариатын газар бичиг цаасхантай зууралдаж байсан, машины бараа ч хараагүй. Тэгсэн чинь сая түргэн зуур шалгаад, цэргийн техникч цол өгчихсөн юм.

– Армид тэгэх боломж байх уу?

– Манайд чинь танилын татаас Совнаркомынхоос илүү. Хаа сайгүй шүү дээ.

– түүний яагаад батальонд элдвийн новш аваад байсныг одоо ойлголоо. Чи тэрнийг яаж мэддэг юм?

– Борька Нестеровыг санаж байна уу?

– Саналгүй яахав.

– Чи түүнд юу гэсэн шог шүлэг зохиосон билээ? Бодонгийн махан шабмаг, халбага цагаан будаа нь хө, Борисын булшин дээр хамгийн сайхан хөшөө болно оо хө. Энэ шабмаг ч чамд айхтар үнэтэй туссан даа.

– Тэгсэн гээд Саша мушилзав.

– Борька Нестеров Ерөнхий газар алба хашиж байгаа. Тэр л надад Коробковын тухай ярьсан юм. Тийм учраас армид хэнтэй ч таарч мэднэ. Энд бол чи надтай хамт тайван байх болно, би чамайг гомдоолгохгүй. Бод. Чамайг бодож чадахгүй бол төлөөнөөс чинь би шийднэ: өнөөдөр илтгэх хуудас биччихнэ!

– Дима, чи битгий тэгээрэй, чамаас гуйя. Чи тэгэхгүй гэж ам өг гэж Саша нээрэнхээсээ хэлэв.

– Дэмий л юм хийж байна даа, Саша... Байлдмаар байна уу? Фронт дээр буруугаа цайруулж, сайн нэрээ сэргээнэ гэж найдаа юу? Бүү тэгж найд! Тэнд гээд тэрээр хуруугаараа тааз руу зааж, – Тэнд юу ч өөрчлөгдөөгүй. Харин ч эсрэг юм болж байгаа! гэв.

– Надад ямар ч буруу байгаагүй, байх ч үгүй. Надад тэдний өршөөл хэрэггүй. Би ч бас тэднийг өршөөх бодолгүй байна. Би бол эцсийн эцэст эрх чөлөөг хүсч байна. Тэнд, тэр фронтод, жолооны ард, би юуны төлөө амьдарч байгаагаа эцсийн бүлэгт мэдэх болно, тэгээд амь эрсдэхдээ хүрэх бол юуны төлөө амиа өгч байгаагаа мэдэж байх болно. Энэ бол миний хувьд нэгэнт шийдсэн асуудал.

– За яахав! Шийдсэн юм бол юу гэхэв. Харин одоо бол хоёулаа явж юм идье, чи чинь галт тэрэгнээс шууд ийшээ ирээ биз дээ, нэг жаахан юм амсая.

– Дима, би ээжтэйгээ олон жил уулзаагүй.

– Уучлаарай, гэхдээ чи бид хоёр хамтдаа жаахан суух ёстой. Утсаар ярьж байгаад уулзацгаая, Борька Нестеровыг дуудсан ч болох юм.

– Дима, би чамд шулуухан үнэнээ хэлчихье. Манай сургуулийнхнаас ганц чамаас өөр хүнтэй уулзах гойдын эрмэлзэл надад алга. Чамтай уулзлаа, энэ бол миний хувьд аз жаргалтай сайхан өдөр. Энэ долоон жилд иймэрхүү өдөр тийм ч олон байгаагүйг чи ойлгож байгаа.

– Ойлголгүй яахав, Саша, ойлгож байна хэмээн Руночкины хоолой чичрэв.

– Метро хэвийн ажиллаж байгаа юу?

– Юуны чинь метро?! Надад хашаагаар дүүрэн машин байна. Чамайг ёстой салхи татуулаад хүргээд өгнө.

Найман давхар хэдэн байшингаар хүрээлэгдсэн худаг шиг давчуухан байрны дотоод талбай. Хүүхэд ахуй цагийнх нь талбай. Орцнуудын дэргэд устай торх, элстэй хайрцаг, бусад нь яг хуучнаараа. Өөрийнхөө гар хийцний хүлээн авагчид антенн тогтоохоор авиран гарч байсан нөгөө л түймрийн шат. Одоо тэр гар хийцний хүлээн авагчийг хэн ч мэдэхгүй, тэгэхэд бол Коминтерний нэрэмжит зөвлөлтийн анхны радио станц нэвтрүүлэг хийж эхэлж байж билээ. Аль хэзээний явдал, гэхдээ ой тойнд тодхон байна.

Тэгэхэд сурах бичиг, дэвтрээ хулдаасанд боочихоод, аль болох урт оосор хийгээд зодолддог сон... Чухам энэ талбай дээр л зодолдоно, тэгэхэд зайтай, цэлгэр юм шиг санагддаг байж. Ийшээ ингэж түргэн, долоохон жилийн дараа эргэж ирнэ гэж бодож байсангүй. Дайн ийм боломж олголоо. Зөрсөн хэдэн хүний царайг тогтож харсан боловч таних хүн алга.

Саша давхартаа гүйж гараад, хонх дарж амжаагүй байхад хаалга нь нээгдэж, ээж нь түүнийг тэврэн цээжинд нь толгойгоо наагаад, мэгших зуур, орц руу орохыг нь харснаа хэлэх гэж оролдов.

– Ээж минь, тайвшир, тайвширч үз хэмээн Саша толгойг нь үнслэв. – Харж байгаа биз дээ, бүх юм дажгүй, бүх юм хэвийн байна.

Тэр хоёр дотогшоо оров. Ээж нь сандал дээр суугаад түүний гарыг атгасан ч, уруул нь өмөлзсөөр байв.

– Ээж ээ, уйлдгаа уйлсан, харуусдагаа харууссан, одоо болоо!

Саша үүргэвчнээсээ боодолтой юм гаргаж, махан нөөш, талх, зөөлөн чихэр сэлтийг ширээн дэр гаргаж тавилаа.

– Энэ миний хүнс, алив намайг хооллож ундал, би өнөөдөр юу ч идээгүй яваа...

– Өө тэгэлгүй яахав, одоо, одоо, ээжийнх нь бүх юм бэлэн байгаа.

– Надад алчуур өгчих, гараа угаая.

Авдар руу ойртож очвол, шилтэй жаазанд өөрийнх нь зураг байна. Өөрт нь ийм том зураг хэзээ ч байгаагүй, энэ зургийг нэг л сайн санаж өгөхгүй байв.

– Танихгүй байна уу?..

– Танихгүй байна.

Ээж нь хайрцагнаас жижигхэн зураг гаргаж ирэв. Энийг бол Саша санаж байна. Тэдний зургийг хөл бөмбгийн тэмцээний дараа авсан, Саша тэгэхэд дүүрэгтээ тэргүүлдэг “Красная роза” үйлдвэрийн багт тоглож байсан.

Тэр үнэхээр ийм бараг хүүхэд шиг, итгэмхий царайтай байсан гэж үү?!

– Бид энийг томруулсан юм, чиний том зурагтай баймаар санагдаад гэж ээж нь тайлбарлав.

“Бид” гэж хэлэхээр нь Сашагийн зүрх шимшрээд явчихав.

– Зурагчин хоёр хувь буулгаж өгсний нэгийг Варя өөртөө авч, ханандаа хадсан, гэтэл зэргэмцээд Сталины хөрөг байх, санаж байна уу, Нина их үнэнч гишүүн байв даа.

– Би мөн сайхан улс дээр орж ирэв ээ хэмээн Саша инээд алдав. Гэхдээ ээж нь өөрөө юм ярьж магадгүй гэж бодоод Варягийн тухай элдвийг асуусангүй.

– Гараа угаа гэж ээж нь сануулаад, – Би хоолоо ийш нь аваад ирье гэв.

тэрээр өрөө рүү эргэж орж ирээд,

– Чамаас асууя гэж саналаа, Вахтанговын театрын хажуугаар өнгөрсөн чинь нэг л биш ээ, бөмбөгдүүлсэн юм уу даа?

– Өө чи мэдээгүй юм уу? Жүжигчин Куза алагдсан, чи түүнийг санаж байна уу?

– Саналгүй яахав. Манай сургуульд жүжгийн дугуйланг удирддаг байсан юм.

– түүнийг чинь Румыны хааны хамаатан гэлцэх юм.

– Би мэдэхгүй, магадгүй л дээ. Германууд Арбатыг тухайлан онилсон болж байна уу?

– Арбатыг ч бөмбөгдсөн, бас Гоголийн цэцэрлэгт гудам, Их театр энэ тэрийг ч бөмбөгдсөн.

Ээж нь татсан шинэ өргөст хэмхтэй манжингийн хүйтэн шөл, махтай хуймаг, цардуултай жимсний зутан ширээн дээр авчирч тавив. Бүгд Сашагийн хар багаасаа дуртай идээ.

– А-яа-яа! Та нарт чинь тасалбараар ийм юм өгдөг хэрэг үү?

Ээж нь хариу хэлсэнгүй, ширээний ард суугаад хүүгээ ширтэв.

– Харж ханахгүй байна уу?

Ээж нь бас л дуугарсангүй, түүнийг харсан чигээрээ сууж байна. Уруул нь дахиад өмөгнөв.

– Сашенька, чи ямар төлөвлөгөөтэй байгаа вэ, хэзээ явах юм?

– Маргааш өглөө.

– Чамайг ирнэ гэж би Вера, Полина хоёрт дуулгасан, тэдэнтэй уулзах хэрэгтэй, Сашенька, ямар ч гэсэн нагац эгч нар чинь, чамд хичнээн хайртай билээ дээ.

– Би өнөөдөр оройг чамтай л өнгөрөөмөөр байна.

– Би ч тэгмээр байна, гэтэл тэр хоёр тэгэхэд чамайг Бутырькийн шоронд өөрсдийг нь

дуудуулж уулзаагүй гэж хичнээн халагласан гээч. Би бас Нина Ивановад дуулгасан.

– Нинад аа? Энд байгаа юм уу?

– Тийм, хуучин байрандаа амьдарч байгаа. Манайхаар орж гарна, чамайг сураглана. Өчигдөр утасдахаар нь, “Сашатай дөнгөж сая ярилаа, маргааш ирнэ” гээд хэлчихсэн юм.

– Макс хаана байгаа хэрэг вэ?

– Макс фронтод.

– Нинатай ч юу байхав, энэ байшинд юм чинь хэдэн минут ороод гарч болж байна. Харин хоёр эгч гэдэг чинь оройжингийн юм болно шүү дээ.

– Тэд нар нэг их удахгүй. Шөнө гудамжаар үзэгдэж болохгүй, Вера маргааш албандаа явна, Полина хамгаалалтын байгууламж барихад дайчлагдсан, тэднийг өглөө зургаад цуглуулж машинаар авч явдаг юм.

– За яахав, ирцгээг л дээ. Эцэг хаагуур байна?

– Эцэг үү? Эцэг чинь Москвад байгаа. Өрөөгөө арилжаад, Замоскворечье хавьд байгаа, авгайтай, нэг охинтой болсон, бид хоёр албан ёсоор салсан, би зөвшөөрсөн бичиг, паспорт хоёроо өгсөн, тэр л бүгдийг нь ёсчлон бүрдүүлсэн. Би хаягийг нь мэдэхгүй, харин утас нь байгаа, чи утасдаж болно.

– Яахаа би шийднэ.

тэрээр ширээний араас босч, өрөөн дундуураа явж номын тавиурынхаа тэнд зогсоод гайхшран харав.

– Михаил Юрьевичийн номнууд энд яагаад ирчихээв?! Жирмунский, Томашевский, Тынянов... Уран зохиолын болон театрын зүтгэлтний дурдатгалууд... Анри-де-Ренье, Жюль Ромен, Пруст, Гофман...

– Их л хачин юм болсон... Михаил Юрьевич үхэхээсээ жаахан өмнө тоосонд аж төрж залхлаа гэх маягтай юм хэлж, өөрийнхөө номыг Варя, та хоёрт хувааж хуваарилсан. Бид нар учраа олохгүй байсан чинь мань хүн тэгнэ гэж зүтгээд. Варяг: “Та Москвагаас явах гэж байгаа юм уу?” гэж асуухад, “Нэг маягийн тийм ч юм уу” гэж хариулж. Тэгээд Варя сайхан сэтгэлтэй амьтан хойно чемодан саваа эмхлэхэд нь тус больё гэж л дээ.

– Би Михаил Юрьевичид их дассан байсан, яагаад амиа хорлочихсон юм бэ? гэж Саша асуув.

– Бүх Холбоотын тооллого болж, зургаан сая хүн үхсэнийг нуухыг тэднээс шаардсан, мань хүн тийм юманд оролцохыг хүсээгүй. Варя тэгж хэлсэн юм билээ. Шоронгоос айсан байх, зодно, эрүүдэн шүүнэ гэж айсан байх. Бид нар тэгж бодож байгаа юм.

Ээж нь доошоо харж хэсэг чимээгүй болов...

– Саша, юу юу, чамайг...

Саша ээж рүүгээ очиж тэврэв.

– Үгүй ээ, намайг зодож, эрүүдэж байгаагүй, тэр явдал чинь хожим эхэлсэн зүйл.

Хаалга тогшсон чинь хөршийн Галя орж ирээд, Сашаг үнссэнээ уйлчихав.

– За тээр, энэ нь бас уйлчихлаа гэж Саша өгүүлэв.

Галя өтөлжээ. Хуучин бол дуу шуутай, гал зууханд бухимдаад начигначихдаг, тэгснээ дорхноо тайвширчихдаг, өрөвчхөн авгай асан, Сашаг баригдаад явахад халаас руу нь хайрцаг тамхи сэм хийж билээ.

– Чи өөр болжээ хэмээн Галя эхрэв. – Ямар ганган эр байлаа даа, манай энэ хавийнхан чамайг “Ганган Сашка” гэдэг байсныг санаж байна уу?

– Санаж байна гэж Саша мушилзаад, – Петя хаа байгаав? гэж хүүг нь асуув.

– Хааныг мэдэхгүй! Мэдэхгүй. Хэзээ ч олж мэдэхгүй байх гэж айх юм. Бүр дайны өмнөөс цэрэгт алба хаасан, хорин оных шүү дээ, Белорусст байсан юм. Тэгэхээр яг улаан галд орчихсон хэрэг. Захиа ч алга, сураг ажиг ч алга.

– Та битгий цөхрөнгөө бар, тэндхийн ангиудтай шуудан харилцаа тасарсан байгаа, захиа ирнэ.

– Хаашаа ирэх вэ дээ, Сашенька минь, Москвагийн хаяанд хэдийнэ нуувч ухаж байна.

– Баруун зүгт арми байлдаж байгаа, бүслэлтээс гарч байгаа. Та харж л байгаарай, Петя эргээд ирнэ, би танд зөгнөн хэлж байна.

– Сашенька, баярлалаа, сайхан үг байна. Чамайг бурхан өршөөж амьд мэнд явах болтугай гээд Галя түүнийг дахин үнсэв. – Чамайг ч зовоолоо, Софья Александровнаг ч зовоолоо. Бид нар ердөө хөндлөнгөөс л харж байлаа шүү дээ. Одоо ингээд бүх ард түмнээрээ зовох цаг ирж.

Галяг гарсны дараа Софья Александровна,

– Энэ чинь муугүй хүүхэн, бид хоёрт ойлголцдоггүй юм гардаг байсан, гэхдээ бүхэлдээ учир нь олдсон. Саша минь, одоо хүмүүс зовлонд унаад, арай дээр, арай өрөвч болж байна гэв.

Саша гэнэт ширээ шаав.

– Хүний шаарнууд, увайгүй шидлүүд! “Алга дарам ч газраа өгөхгүй”... “Зөвхөн хүний нутаг дээр”... “Бага цусаар”... гэх мэт чалчаад байсан. Гэтэл германууд хэдийнэ Смоленскт ирчихээд байна.

– Тэд нар үнэхээр ийшээ ирнэ гэж үү, Саша?

– Мэдэхгүй. Ирэхгүй ч магадгүй. Манай аугаа их суут маань дахиад хэдэн сая тиймэрхүү Петька, Ванька, Гришкаг золионд гаргана, тэглээ гээд түүнд пад байх уу?! Би Галя эгчийн нүд рүү харж чадахгүй байлаа. Петя нь алуулсан, эсвэл олзлогдчихсон. Гэтэл олзлогдохыг эх орноосоо урвасан хэрэг гээд зарлачихсан.

– Сашенька, мэдээтэй, хэрсүү л байж үзээрэй, энэ тухай ярихгүй нь дээр... Би чамайг зүгээр жолооч хийж байгаад баяртай байна, хэний ч төлөө хариуцлага хүлээхгүй амар.

Гудаанд хонх дуугарав.

– Хоёр эгч чинь ирлээ гээд Софья Александровна босов.

Нээрэн тэр хоёр аж. Хуучин янзаараа эрч хүчтэй, ажил хэрэгч хэвээр байгаа том эгч Вера нь түүнийг чанга тэвэрснээ, өөрөөсөө холдуулж хараад,

– Хараач хө, ямар эрэлхэг цэрэг болоо вэ! Ийм учралаар заавал уух хэрэгтэй! гээд цүнхнээсээ шил архи гаргаж ирэв. Бас бэлэгтэй ирж. “Жиллетт” гэдэг гадаадын сахлын хутга, хоёр багц ялгастай.

Номхон, инээвхийлсэн бага эгч Полина нь алгын чинээ бяцхан ном авчирч өгсөн нь Пушкины шүлэг, найраглал аж.

– Чи Пушкинд дуртай шүү дээ, энэ ном халаасанд чинь багтана.

Ширээнд сууцгааж, бага зэрэг ууцгаав. Ээж нь юм хум янзалж, гал тогоо руу орж гарна, хоёр эгч яриа дэлгэлээ. Верагийн охин эмч, цэргийн эмнэлэгт ажилтай, хүү нь их бууны дунд сургуульд сурч байгаа, энэ жил төгсгөөд фронт руу явуулна. Полинагийн нөхөр цэргийн сурвалжлагч, хүү нь дөнгөж арван долоо хүрсэн, гэвч цэргийн хэлтэс хэдийнэ бүртгэлд авчихсан гэнэ.

– Зөвхөн бид нар, эгч дүү гурав л ерөнхий командлалын эцсийн нөөцөнд үлдлээ гэж Вера гунигтай тоглож өгүүлэв.

Хоёр нагац нь Сашаг цуст махны машинаас салсанд баяртай байв.

– Бурханы ачаар, үгүйдээн чамайг харах заяа байж, үлдсэнийг нь хүлээж чадах эсэхийг бүү мэд... гэж Вера өгүүлэв.

– Дажгүй ээ, энэ ширээний ард бид дахиад уулзана.

Улигт үг, гэвч Сашад өөр хэлэх юм олдсонгүй.

– Гитлерийг ялаад өөрөөр амьдарч эхэлнэ гэж Полина үг хавчуулав.

Нина ирж, босгон дээр зогтуссанаа бас усан нүдэлж Сашаг тэврэн үнсэв.

– Ниночка, суу гэж Софья Александровна түүнийг урив.

Нина хоёр авгайг харснаа,

– Би цагаа олсонгүй юу? гэв.

– Харин ч яг олж ирлээ хэмээн Саша инээж, – Бидэнтэй ууна даа гэв.

Нина жижиг шилэн аяганы ёроол руу зааж,

– Яг л иймхэнийг гэв.

Хоёр нагац нь дахиад жаахан суузаснаа, гэр хол, маргааш эрт ажилтай гэлцэн явах юм болов. Саша тэднийг шат хүртэл үдэж өгч, харилцан гар даллалцан салаад, эргэж ирж Нинатай зэрэгцэн суув.

– Хүү чинь хаа байна?

– Эмээ дээр нь орхичихсон.

Саша түүнд Лена, Глеб хоёрын тухай ярив.

– Ийм л гунигтай явдал. Макс, Варя энэ тэр яаж явна?

– Максим Алс Дорнодод, дивизи бүрдүүлж байгаа. Варя цэргийн барилгын газар, Москвагийн эргэн тойрны хамгаалах байгууламжийн төслийг хийлцээд, хөдөөгүүр тэнэсэн амьтан яваа, бид хоёр уулзана гэж байхгүй, хааяа утсаар л ярих юм. Би сургуульд ажиллаж байгаа. Эх оронч хүмүүжил олгож байна... гээд Нина инээв.

– Манай сургуульд уу?

– Үгүй ээ, өөр дүүрэгт гэснээ түүн рүү харж, – Манай үеийнхэн тэсэх болов уу? гэв.

– Хэн нэг нь үлдэнэ, амьд мэнд гарна.

– Ганцхан Шарок үлдэх болов уу гэж айх юм. Шарок байлдахгүй. Бас Вадим Марасевич ч байлдахгүй. Далиманд хэлэхэд, би саяхан түүнтэй таарсан, цэргийн нэг сэтгүүлд байгаа юм уу даа, “Пограничник” гэсэн байх, тэгэхээр армид байгаа ч юм шиг, гэхдээ байлдах хэрэгцээ байхгүй. Бас аль хэзээний ахмад цолтой гээд бодчих. Ингэхээр Шарок Марасевичтэйгээ л үлдэнэ.

– Зүгээр, чи бид хоёр ч бас жаахан аж төрнө.

– Саша, надад захиа бичиж байгаарай.

– Заавал бичнэ.

Тэгж тэгж ээжтэйгээ хоёулхнаа үлдэв. Ээж нь түүнд буйдан дээр ор засч өгсөн боловч зөндөөн удаан ярьж сууцгаав.

– Сашенька, би чамаас гуйя, чи хулчгар хүн биш, би мэднэ, гэхдээ чи дэндүү нэрээ хичээдэг, тийм учраас болгоомжгүй загнах явдал байх юм. Чи гучтай, гэхдээ чухамдаа бол чи зовсноос биш амьдарсангүй. Өөрийгөө хямгадах хэрэгтэй, дайны дараа бүх юм өөрчлөгдөнө.

– Чи тэгж бодож байна уу?

– Би тэгнэ гэж итгэлтэй байна гээд хаалга руу хялайн дуугаа намсгав. – “Эх орныхоо төлөө”, “Сталины төлөө” гэдэг чинь шившлэг, зүгээр ёс шүү дээ. Өнгөрсөн дайнд ч: “Эх болсон Оросын төлөө”, “Эцэг болсон хааны төлөө” гээд бас л тийм байсан. Гэтэл хааныгаа яасан билээ? Орост бүх дайны дараа ямар нэг юм өөрчлөгдөж ирсэн. Севастополийн дараа тариачны шинэчлэл, Орос-японы дайны дараа 1905 оны хувьсгал, дэлхийн дайны дараа Хоёрдугаар сарын хувьсгал.

– Чи ямар гээчийн өөрчлөлтийг хүлээж байна?

– Мэдэхгүй. Нэг л юмыг мэдэж байна: ард түмнийг зовоож болоо! Орос хэвийн улс болох ёстой.

– Өрнөдийнхний үлгэрээр үү?

– Тийм, тэгсэн ч яахав.

– Чиний горьдлого биелэхгүй л болов уу. Хувьсгалаар тунхагласан нийгмийн шудрага ёсны үзэл санаа ард түмний ухамсарт гүнзгий шингэсэн. Хэрэв бид ялах юм бол ард түмэн гарцаа тэр ленинч цаг үеэс хайх болно.

– Сашенька, намайг уучлаарай, битгий гомдоорой, чиний Ленинд яаж ханддагийг чинь би мэднэ, гэхдээ түүнийг өвтэгш мэт болгох хэрэггүй. Чи тэгэхэд жаахан байсан, би түүний үед амьдарч байсан, цус урсгах, буудан алах, газар давхарт тамлах явдал чамлахааргүй байсан.

Саша инээд алдав.

– Долоон жил саланга байсны эцэст бид хоёр улс төрийн тухай ярина чинээ даанч бодсонгүй.

– Үгүй ээ, Сашенька минь, энэ бол миний хувьд улс төр биш, миний хувьд бол энэ бол чиний хувь заяа. Чамайг Бурхан хямгадаасай гэж мөргөж залбирч байгаа. Тийм учраас би дайны дараа юу болох тухай бодож байна.

– За яахав, эхлээд Гитлерийг хөөчихье, дараа нь юу хийхийгээ шийдье. Харин одоо бол би унтахаар хэвглээ, за юу ээжээ, үхтлээ ядарсан байна.

тэрээр хувцсаа тайлан хэвтэхэд, ээж нь цагаан даавуугаар хучиж өгөөд, унтмагц нь нүслээ.

Саша, цэргийн техникч Овсянников хоёр Москвагаас явуулын засварын машин хөөж ирлээ: жижигхэн вагон чиргүүлтэй, битүү тэвштэй машин, дотроо токарийн болон өрмийн суурь машин, дархны вандан, аралба, багаж хэрэгсэл, гагнуурын алх, шахуурга, цахилгаан гагнуурын аппарат гэхчилэн өчнөөн юмтай. Саша баазын даргатай дээд сургуульд хамт сурч байж, тийм учраас Сашагийн ачаар ийм мундаг машинтай боллоо гэж Овсянников дайралдсан болгонд ярьж байв. Гэвч баярлаж хөөрөх цаг байсангүй. Наймдугаар сар дуусах тийшээ хандаж, батальон бүрдүүлэх хугацаа тасалдаж байв. 1890-1904 онд төрсөн цэргийн үүрэгтнүүдийг нэмж дайчлах тухай зарлиг гарч, батальонд ахмад насны жолооч нар ирэв. Механик Василий Акимович Синельщиков бас дайчлагдсан тул түүнийг явуулын засварын газрын даргаар томилжээ.

Үгүйдээн эхний суманг бушуухан явуулах гэж яарцгааж байв. Тийш нь Овсянниковыг салааны даргаар шилжүүлсэн тул, Саша ч хамтдаа шилжин ирж, Проценко гэдэг сэргэлэн жолооч залуутай ханиндаа машин хүлээж авахад тусалдаг болов. Тэр залууд олж чадахгүй юм гэж байхгүй, хаа ч нүүрийн буянтай. Юлдашев түүнийг хангамжийн чиглэлээр ажиллуулахыг завдсан боловч жолооч болгон амин чухал байна гэж нэгдүгээр сумангийн дарга Березовский эсэргүүцжээ.

Березовский нэг удаа Сашатай ярилцав. Цех нэг умгар өрөөтэй, тэр хоёр тэнд бичгийн ширээний ард тухлан сууцгаав.

– Панкратов, таныг тээврийн дээдэд сурч байгаад дөрөвдүгээр дамжаанаас гарсан гэж би дуулсан. Тэгсэн юм уу?

– Тийм, тэгсэн юм.

– Би таныг сумангийн техникийн туслахаар томилох санаатай байна. Ийм албан тушаалтай болвол танд цэргийн техникч цол олгох санал тавих боломжтой болно. Таны боловсролын тухай бичиг баримт бий юү?

Энэ хүн Сашад таалагддаг, итгэл төрүүлдэг хэдий ч Саша,

– Надад боловсролын тухай бичиг баримт байхгүй гэж хариулав.

Березовский гайхан нүдээ бүлтийлгэв. тэрээр үс нь буурал суусан ч, сахал, хөмсөг нь тас хар.

– Сургуулиасаа шаардаж болно, таныг хүсвэл бид бичиг явуулъя. Эсвэл танд Москва явах томилолт өгсөн нь дээр байх, нэг хоногт амжина шүү дээ.

– Би Москва явахгүй, сургуулиас юм шаардахгүй. Би бол жолооч, тэр чигээрээ байя.

Тэр хоёр нэг хэсэг нүд нүд рүүгээ эгцлэн харж байсны эцэст Березовский,

– Та, шалгалтад шаардлагатай бичиг баримтыг яаралтай шийтгэн олгохыг шаардсан

батальоны албан бичигтэй очно шүү дээ. Цэргийн байгууллагын шаардлага учраас тэдэнд татгалзах эрх байхгүй гэв.

мань хүн нэг юм гадарлаад байгаа бололтой, өөрөө бас гүвшүүлж явсан байх. Цэргийн албанд зүтгэсэн хүн үүний насан дээр дор хаяхад дэд хурандаа байх ёстой.

– Нөхөр ахлах дэслэгч, би цэрэгт хэзээ ч алба хааж байгаагүй. Хэдий тийм ч жирийн байлдагчид түүний хүсэл зоригийг харгалзахгүй цол олгож болно гэж итгэхгүй байна.

– Дайны цагт бүх юм болно гэж Березовский хатуухан хэлснээ сэдвээ өөрчилж, – Та пулуу, “ЗИС” хоёрын алийг нь авмаар байна? гэж асуув.

– Пулууг.

– Өөрийнхөө дуранд тааруулаад шилж аваарай.

Саша 1940 онд үйлдвэрлэсэн, хөдөөгийн замд нүдүүлчихээгүй, бараг шинэ гэхээр нэг машин сонгож авав. Сумангийн жолооч болгон машинаа тордоно, фронтод муу машинтай бол ёстой балрах юм чинь. Салааны даргаас нэхэхгүй юм байхгүй, хүний аяар Овсянниковыг егзөр жолооч нар элэг барин байдгаар нь шахаж, шар махтай нь хатаана.

Саша нэг удаа түүнд,

– Чи цаадулдаа нэг их битгий бууж өгч бай, толгой дээр чинь гарчихна шүү гэж хэлжээ.

Гэвч Овсянников хатуурхаж эс чадна. Ер нь ч тэр яах сан билээ? түүний захиргааны тасгийн дарга нарын хүч ч мөхөсдөнө. Сашагийн тасгийн дарга нь Мешков гэж цэргийн алба бүрэн хаасан, түрүүч цолтой, туршлагатай жолооч, төлөв сайхан хүн. Жолооч нарт цайлган сэтгэлээр: “Залуус минь, өөрийнхөө толгойгоор аж төрнө шүү, яаж ийгээд аргалцгааж бай, тэр Проценког харахгүй юү, хамаг юмаа өөрөө олж байна” гэнэ...

Удахгүй замд гарна, фронт руу. Чухам хаана очихыг хэн ч мэдэхгүй. Тэдний суман Брянск орчимд шинээр бүрдүүлж байгаа 50 дугаар армийн мэдэлд очно гэж Овсянников Сашад аминчлан хэлсэн. Тэнд л винтов тавьж өгөх юм байж.

Суман бэлтгэл хийсээр. Өдөр нь хичээл хийнэ, үдийн хоолны дараа машин дээрээ ажиллана, хүн болгон чадах чадах юмаа нөөцлөнө.

Замд гарахын өмнөхөн хичээл хийхийг зогсоож, машинуудаа цэнэглэн, чангалах юмыг чангалж, эрэгдэх юмыг эрэгдэв. Жолооч нарт шинель, хувийн хэрэгсэл тавьж өгч, хээрийн шуудангийнх нь дугаарыг мэдэгдэв. Суманд маань ачаа хүргэж өгөх ёстой дивизийн бэлтгэгч нар ирэв. Армийн шаардлагатай залуус.

Долоон цагт жагсаал зарлаж, оройн хоолонд орцгоов. Энэ орой олон хүн юм балгасан боловч санаа сэтгэл гунигтай байцгаажээ.

Хүрэн халиун үстэй, гуниг хурсан цэнхэр нүдтэй Руслан Стрельцов гэдэг сайхан жолооч

залуу оройжин баян дарав. Суман болгон баянтай, машинаар юу хүссэнээ аваад явчих юм чинь. Сайхан дарж байна... Дандаа гунигтай ая. Стрельцов өөрөө ч инээх нь ховор. Хэрдээ сэтгэлийн зовлонтой, нисэх хүчинд орох хүсэл тэмүүллийнх нь дагуу нисэхийн сургуульд явуулах ёстой байтал, бичиг баримт нь цагтаа ирсэнгүй, тэгээд авто батальон руу чихчихэж. Тэгээгүй бол тэнгэрээр нисч явахгүй юү...

Маргааш өглөө нь машинууд хотын зүг эрт хөдөлцгөөв. Хүнсний зүйл, хувцас хунар, шатахуун, тослох материалаа базааж ачицгаав. Хамгийн туршлагатай жолооч бүхий арван машиныг зэр зэвсэг, сум хэрэгсэлд явуулав. Тэгээд суман Рязаниас Михайлов хот хүрэх замын товлосон цэг дээр дөнгөж гурван цагт эмхрэн цугларав. Энд тэднийг батальоны удирдлага, явуулын засварын машин, хээрийн гал тогоо энэ тэр хүлээж байв.

Үдийн хоолоо идэцгээлээ. Машинууд ойн цоорхойд тасаг тасгаараа эгнэн жагсав. Жолооч нар бүхээгнийхээ хажууд зогсоцгоов. Замын цаадах хураагаагүй тариан талбай дээгүүр хар тодол сүрэглэн нисч байна. Тосгонд эрчүүд байхгүй, тариагаа хураах хүн алга, тариа сөнөх нь.

– Но-ом-хон! гэж Березовский командлаад Юлдашев руу эргэж, – Нөхөр батальоны дарга, суман маршаар явахад бэлэн боллоо гэж илтгэв.

– Нөхөд байлдагчид аа, эх орноо эрэлхэгээр хамгаалагтун. Эх орныхоо өмнө хүлээсэн ариун үүргээ биелүүлэгтүн. Манай социалист эх орон мандтугай. Ура! гэж Юлдашев командлав.

– Ура! гэж суман хариуд нь сайн жигдрээгүй дуугаар хашгаралдав. Сайн сургуулилж амжаагүй болоод тэр.

Березовский тасгийн дарга нарыг дуудаж, явах журам, хурд, машин болон, тасгуудын хооронд барих зайг зааварлан тушаал буулгав. Анхны зогсоол Захарово суурин.

Жолооч нар бүхээгтээ орж, мотор дүнгэнэлдлээ.

Суман зүүн өмнө зүгт, Рязань мужийн Михайлов хот руу хөдлөв.

Сталин яаж байлдах гэж байгаагаа улс орондоо үзүүлэв.

Сталин дайн эхлэхээс хоёр хоногийн өмнө хил дээрх хээрийн бэхлэлтэд байр эзлэхийг хориглож байсан нөгөө Баруун фронтын командлагч Павловыг штабынх нь хамт буудан алжээ. Анги, нэгтгэлийн хэдэн арван дарга, генералыг бас буудан алсан байна. Хойшид “Дур мэдэн ухарсан дарга нарыг буудан ална... Олзлогдон бууж өгсөн дарга нарыг бузар оргон зайлагч гэж үзэх, ар гэрийнхнийг нь баривчлах, бууж өгсөн цэргүүдийн ар гэрийг улсын тэтгэмж, тусламжаас хасах... Германы цэргийн ар талд байгаа бүх суурин газрыг эвдэн сүйтгэж, үнсэн товрог болтол галдан шатаах... Хороо болгонд суурин газрыг дэлбэлэх, галдах баг бий болгох. Суурин газрыг устгах талаар эрэлхэг үйлдэл хийсэн гарамгай зоригтнуудыг засгийн шагналд тодорхойлох” зэргийг зарлан мэдэгдсэн байна.

Гэтэл, Сталины айлган сүрдүүлэх тушаалыг үл харгалзан, германууд гурван долоо хоногт 500 – 600 километр давшсан байхад, Зөвлөлт Холбоот Улс бараг сая хүнээ алуулах буюу шархдуулан хохирч, мөн төдий тооны хүнээ олзлуулсан байна. зургадугаар сарын 16-нд Смоленск эзлэгдэв. Ингэснээр Москва орох зам нээгдлээ. Гитлер Улаан Арми бут цохигдсон, дайн ойрын өдрүүдэд германы цэргийн бүрэн ялалтаар төгсөнө гэж дэлхий даяарт зарлав.

Энэ зарлал эртэджээ. Улаан Арми бут цохигдоогүй болж таарч, алга дарам газар болгоноо хамгаалан тулалдаж байв. Германы арми сульданд байж Смоленскт хүрсэн аж. Танкийн тэргүүлэх корпусыг арга буюу хүч сэлбэхээр ухрааж, тэднийг явган цэргээр солиход хүрчээ. Анх удаа аргагүйдсэн хамгаалалтад шилжсэн хэрэг.

Смоленскт зогссоноо Германы цэргийн командлал түр зуурынх гэж үзэж байв. Удахгүй намар болж, зам харгуй нэвтрэхэд бэрх болно, тийм учраас давшилтад аль болохоор түргэн шилжиж Москвад цохилт өгөх хэрэгтэй. Үүгээр дайны төгсгөл шийдэгдэнэ. Гэхдээ Гитлер баруун хойд болон өмнөд чиглэлээр ялалт байгуулна гэж харж байж. Ленинградыг эзэлж, финнүүдтэй нийлэх, Киевийг эзэлж авах, өмнөд холбоотон Румын, Унгар, Италийг зоригжуулах, Украин, Донбассыг булааж авах, Кавказ руу үсрэх тавцан бий болгох, Зөвлөлт Холбоот Улсыг талх тариа, нүүрс, газрын тосгүй үлдээх. Гитлер долдугаар сарын сүүлээр Киев рүү довтлохоор бэлтгэх тушаал буулгажээ. тэрээр, тийнхүү, оросуудад Москвагийн хамгаалалтыг бэлтгэх хоёр сарын хугацаа өгчээ.

Долдугаар сарын 29-нд Жуков Сталинд илтгэхээр явав.

Бүх цэргийн жанжны газар одоо Кировын гудамжны нэг байшинд байрлаж байгаа ажээ. Бөмбөгдөлтөөс хоргодох байр болгосон метроны “Кировская” өртөө рүү агаарын түгшүүр зарласан үед тэр байшингаас түргэн орох боломжтой. Уг өртөөгөөр зорчигч явахыг зогсоож, төмөр замыг нь хашлагаар хаан, буудлын тавцанг хэдэн өрөө болгож тасалсны нэг нь нөхөр Сталиных. Хоргодох байранд Сталин үгэнд орох нь арай дээр байдаг тул агаарын түгшүүр зарлавал Жуков баярлахаар байж. Гэвч тэр мөчид германууд Москваг бөмбөгдөөгүй байсан учраас Сталин өрөөндөө, цонхныхоо дэргэд зогсож байв. Ширээний ард урьдын адил Молотов, Маленков, Берия гурав сууж байгааг хараад Жуков бас жаахан гонсойжээ. Сталин

хоёулхнаа уулзахад бас арай дуулгавартай байдаг аж. Гэвч энэ гурав түүний өрөөнд байнга бөөдийж байдаг юм.

Жуков байдлыг илтгэв. Германууд Киев рүү довтолвол Баруун өмнөд фронтын цэрэг бүслэгдэж болох учраас тэр довтолгоо сүйрэлт уршигтай. Сталин өрөөн дотуураа холхиж, хаа нэг ширээ рүүгээ очиж, газрын зураг харж байснаа зургийн өмнө суув.

– Та юу санал болгож байна?

– Днеприйн баруун эргийг нэн даруй орхиж, зүүн эрэг дээр нь хамгаалалт зохион байгуулах хэрэгтэй.

Сталин Жуков руу муухай харав:

– Киев яах болж байна?

– Киевийг орхихоос аргагүй.

Сталин босч, сандлаа огцом түлхсэнээ, өрөөн дундуураа хэд алхаад буцаж ирж суугаад, харандаа авав.

– Та илтгэлээ үргэлжлүүл.

Жуков зураг дээр Москвагаас холгүй нэг цэгийг заав.

– Ельнийн хошууг германууд хожим Москва руу довтлохдоо ашиглаж мэднэ. Энэ хошууг арилгахын тулд сөрөг цохилт зохион байгуулах хэрэгтэй.

Сталин харандаагаа ширээн дээр хаяв.

– Бас юуны чинь сөрөг цохилт вэ, юун балай юм яриад байна?

тэрээр дуугүй байзснаа, гэнэт цахиртуулан,

– Дайсанд Киевийг өгнө гэж та яаж бодож чадаж байна аа? гэж хашгачив.

– Нөхөр Сталин... хэмээн Жуковын дуу тасалдав. – Намайг дэмий донгосч чадна гэж та үзэж байгаа бол надад энд хийх юм алга... Тийм бол, нөхөр Сталин... – Намайг Жанжин штабын даргын албанаас чөлөөлж, фронтод явуулж өгөхийг хүсье. Би тэнд арай илүү нэмэр болох байх...

Сталин буруу харав.

– Та асуудлыг тэгж тавьж байна уу?! За яахав, бид таньгүйгээр болгоно. Та яв! Хэрэгтэй цагт би таныг дуудна. Энэ цааснуудаа ав! гээд ширээн дээрх зургийг цааш нь түлхэв.

Жуков гарав. Сталин дахиад өрөөн дотуураа холхиж эхлэв.

Чимээгүйн дундаас Молотов эхлээд ам нээв.

– Ямар ч хувилбар, ямар ч санал байхгүй, шууд л Киевийг өгнө гэж байдаг!.. Жидүү хөдөлмөөр юм!

– Хрущев, Кирпонос хоёр ятгачихаж, тэд зүүн эрэг дээр хоргодох санаатай байгаа, тэгвэл тэдэнд арай амар болно гэж Берия мэдэгдэв.

Сталин хонхны товчийг дарав. Жижүүрийн генерал орж ирлээ. Сталин түүнд цахилгаан дуудаж бичүүлэв:

“Киев. Хрущевт. Хэрэв та нар Днеприйн зүүн эргийн зүг ганц ч гэсэн алхам хийх юм бол та нарыг хулчгарууд, урвагчид гэж үзэж хатуу цээрлүүлэх болно”.

Сталин цахилгаанд гарын үсэг зурав.

– Нэн даруй явуул.

Тэгээд дахиад өрөөн дотуураа холхиж эхлэв. Молотов, Маленков, Берия гурвын хоорондоо юу ярьж байгааг сонссонгүй. Бодол болов. Минск, Рига, Вильнюс, Кишинев, Смоленскийг орхилоо, одоо Киевийг орхих гэнэ, маргааш Ленинградыг өгөх санал тавина. Дайсанд өгч байгаа хот болгон ард түмний зүрхийг зүсч байна, ялагдал болгон ард түмний эсэргүүцэн тэмцэх хүсэл зоригийг шантрааж, жолоодогчдоо итгэх итгэлийг сулруулж байна. Бас сонин хэвлэлд өдөр болгон: манай цэрэг тийм тийм хотыг орхилоо гэсэн яг ижилхэн мэдээнүүд... Зөвлөлтийн хүмүүст ийм мэдээ уншихад ямар байгаа вэ?

Сталин Маленков руу хуруугаараа зааж,

– Зөвлөлтийн хүмүүсийн баатарлаг үйлийг илүү өргөн сурталчил. Манай байлдагчид, цэргийн дарга нарын баатарлаг үйлсийн тухай мэдээ бүх мэдээллийн хэрэгслийн гол сэдэв болох ёстой. Бид фашист шулмыг ниргэж байгаа, бут ниргэнэ гэдгийг зөвлөлтийн хүмүүс мэдэж байх ёстой. Энэ тухай ард түмэнд өдөр тутам, цаг тутам ухуулж байх хэрэгтэй гэв.

– Мэдлээ, нөхөр Сталин, одоо заалт өгье гээд Маленков өрөөнөөс гарав.

Жижүүрийн генерал,

– Нөхөр Ворошилов Ленинградаас залгаж байна гэж илтгэв.

Сталин утсаа авав.

– За, чамаар юу байна?

Чимээгүй сонссоны эцэст ингэж хэлэв:

– Би одоо яах тухай заалт дуудаж бичүүлье, энэ чамд ч хамаатай... гэснээ жижүүрийн генералд бич гэж тушаав. – “Германы новшнууд цэргийнхээ өмнө өвгөд, эмгэд, авгай, хүүхэд

явуулж байна гэцгээж байна. Большевикуудын дундаас тийм төлөөлөгчдийн эсрэг зэвсэг хэрэглэх боломжгүй гэж үзэж байгаа хүн гарсан гэцгээж байна. Хэрэв большевикуудын дунд тийм хүмүүс байгаа бол, тэд германы фашистуудаас аюултай учраас тэднийг эхний ээлжинд устгах хэрэгтэй. Миний зөвөлгөө: Уяхан сэтгэл бүү гарга, дайсныг, түүний өөрийн эрхтэй эрхгүй хань хамсаатан бологсдыг нам цохиж бай. Германуудыг, тэдний төлөөлөгчдийг хэн байхыг үл харгалзан хайр найргүй хядаж бай, өөрийн буюу хүний эрхээр дайсан болсныг үл харгалзан аливаа дайсныг хиар хяргаж бай”.

Сталин дуудаж гүйцэв.

– Бүх фронт командлагч нарт нэн даруй явуул.

Тэгээд утсандаа,

– Чи мний юу хэлснийг сонсов уу? Бүрэн сонссон уу? Ямар большевикуудыг би хэлж байгааг чи ойлгов уу? Тийм, тийм, чухам тэд нар чинь! Ойлгосон чинь маш сайн байна.

тэрээр утсаа хаяад, дахиад өрөөн дундуураа холхиж эхлэв. Клим дүйрэн, гол санааг нь сарниулчихлаа... Яагаад Киевийг өгөх ёстой юм бэ? Баруун өмнө чиглэлд хамгийн шилдэг ангиуд төвлөрсөн байгаа, тэрээр чухамхүү тэр чиглэлээр гол цохилт ирнэ гэж хүлээж байсан шүү дээ. тэрээр ухрахыг хориглосон шүү дээ! Гэтэл одоо Жанжин штабын дарга ухрахыг санал болгож байна! Шившиг! түүнд ийм жанжин штабын дарга хэрэггүй!

тэрээр дахиж хонхныхоо товчийг дараад, жижүүрийн генералд Жуковыг дуудах үүрэг өгөв.

Жуков ирлээ.

– Тэгэхээр ийм байна, нөхөр Жуков, бид энд зөвлөлдөөд таныг Жанжин штабын даргын үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдлээ. Энэ албанд Шапошниковыг томилно. Таныг практик ажил дээр ашиглана. Байлдааны нөхцөлд цэрэг командлах туршлага танд бий. Байлдаж байгаа армид таны ашиг тус илүү байх болно.

– Хаашаа яв гэж тушаах сан бол?

– Та Ельнийн тэндэх ажилбарын тухай илтгэж байсан. Тэгэхээр түүнийгээ барьж авч хий. Та, мэдээж, батлан хамгаалах ардын комиссарын орлогч, Бүх цэргийн жанжны газрын гишүүн хэвээр үлдэнэ.

– Явахыг зөвшөөрнө үү?

– Ажлаа Шапошниковт хүлээлгэж өг, тэгээд яв.

Жуковыг ажлаас нь халснаас хойш Киевийг өгөх, Днеприйн баруун эргээс цэрэг ухраах талаар Жанжин штабт ганц үг ганхийх хүнгүй болжээ.

Долоо хоногийн дараа Сталин өөрийгөө Ерөнхий Дээд командлагч гэж зарлав.

Жуков дээд удирдлагаас зайлуулагдсан хэдий ч зүрх гарган, наймдугаар сарын 19-нд Гжатскаас Сталинд ийм цахилгаан явуулав:

“Дайсан өөрийн бүх тэргүүлэх хөдөлгөөнт болон танкийн ангиудыг өмнөд чиглэл рүү шилжүүллээ. Санаа нь: Баруун өмнөд фронтыг ар талаас нь цохиж бут ниргэх. Энэ санаагаа хэрэгжүүлж эхлэнгүүт нь дайсны жигүүрээр цохилт өгөх шаардлагатай”.

Хариу нь ийм байж:

“Германууд давшиж мэднэ. Тэгүүлэхгүйн тулд Еременкогээр толгойлуулан Брянскийн фронт байгуулсан. Бусад арга хэмжээ ч авч байгаа. Германуудын давшилтыг зогсооно гэж найдаж байна. Сталин. Шапошников”.

Жуков энэ цахилгаанд сэтгэл гонсойж, Шапошниковт утасдахад цаадах нь шууд ингэж хэлжээ:

– Брянскийн фронт магадгүй цохилтыг таслан зогсоож чадахгүй. Гэвч Еременко Сталинтай ярихдаа дайсныг бут цохино гэж амласан.

Энэ нь үнэн ажээ. Еременко Сталин дээр орохдоо итгэлтэй царайлж, манай бүтэлгүйтсэний шалтгааны талаарх асуултад оновчтой хариулж байсан байна. Гудерианы Киев рүү урагшилж байгаа тухайд,

– Би энэ муу новшийн Гудерианыг бут цохихыг хүсч байна, ойрын хэдэн өдөрт гарцаагүй бут ниргэнэ гэж байжээ.

Сталин түүнтэй нөхөрсөгөөр ярилцсан аж. Тэгээд гарсных нь дараа,

– Энэ хэцүү нөхцөл байдалд бидэнд хэрэгтэй хүн чинь яг энэ байна гэжээ.

Еременкогийн зан аяг түүнд аятайхан санагдаж. Шийдэмгий, чигч муйхар, согсоотын зальжин зантай, гэхдээ дуулгавартай. Жуков ч бас дуулгавартай, гэхдээ арга буюу хүлээн авч байгаагаа харуулан хараа буруулна. Жуков дэргэд байх нь яршигтай: жанжныхаа хувьд нөхөр Сталинаас илүү гэж итгэнэ, цэргийн стратеги гэдэг бол юуны өмнө Жуковын гадарлах юм байхгүй улс төрийн бодлого гэдгийг ойлгохгүй. тэрээр дотроо эсэргүүцэж байгаа хэнийг тэвчихгүй сэн, гэтэл Жуковыг тэвчээд байгаа, яагаад гэвэл Жуков түүнд найдвартай байдлын мэдрэмж төрүүлдэг цорын ганц хүн. Энэ байдал түүнийг бас дарамтлана, яагаад гэвэл тэрээр зөвхөн өөртөө найдаад сурчихсан хүн. Жуковыг халснаар сэтгэлийн энэ зовлонгоосоо салсан. Жуков хэрэгтэй, гэхдээ зохих зайнд байлгах ёстой. Жуков ӨӨР шиг нь хүнд гартай, Жуков хүнийг хайрлахгүй, гарз хохирлыг тоохгүй, түүний даалгаврыг хамгийн бэрх газруудад биелүүлж байх болно. Энд Еременко ажиллана. Амласан ёсоороо Гудерианыг ниргэчихвэл, тэр цагт нь Жанжин штабын даргаар томилж болно.

Еременко Гудерианыг ойрын хэдэн хоногт битгий хэл хожмын өдөр ч бут ниргэсэнгүй. Германууд өмнө зүгт амжилттай давшсаар байлаа. Еременко шархадсан тул түүнийг Тимирязевийн нэрэмжит хөдөө аж ахуйн академийн байранд буй цэргийн эмнэлэгт авчирчээ.

Тэнд байхад нь нөхөр Сталин эргэж, түүнийг урьдын адил үнэлэж байгаагаа харуулсан аж: гагцхүү шархадсанаас болоод амлалтаа биелүүлж чадсангүй гэж байх нь. тэрээр хүний тухайд алдахгүй.

Есдүгээр сарын 11-нд Сталин Крипоност: “Киевийг бүү орхи, гүүрнүүдийг бүү дэлбэл” гэж тушаав.

Долоо хоногийн дараа, есдүгээр сарын 19-нд Киев унав. Зөвлөлтийн 665 мянган цэрэг, офицер олзлогдов.

Крипонос, түүний штаб тулалдаанд амь эрсэджээ.

Сталин түүний тухай,

– Зоригтой хүн байсан, ард түмэн түүний дурсгалыг хүндэтгэж байх болно гэж хэлсэн ажээ.

Харин энэ ялалтаар жигүүрлэсэн Гитлер Москва руу довглох тушаал өгсөн байна. Гэхдээ тэрээр Киевийн төлөө тулалдаанд хоёр сараа, найм, есдүгээр сараа алдсан юм. Ийм хугацаа алдсан нь үйлтэй юм болжээ.

Германыг Зөвлөлт Холбоот Улс руу довтолсон өдөр Английн ерөнхий сайд Уинстон Черчилль Лондонгийн радиогоор үг хэлжээ:

“Сүүлийн 25 жилд надаас илүү коммунизмыг тууштай эсэргүүцэгч байгаагүй. Би коммунизмын тухай хэлж байсан нэг ч үгээ буцааж авахгүй. Гэтэл одоо өрнөж байгаа үзэгдлийн дэргэд тэр бүхэн маань ёстой бүүдийж байна. Өнгөрсөн үе бол гэмт хэрэгтэйгээ, галзуу солиот үйлдэлтэйгээ, эмгэнэлт явдалтайгаа алга болдог. Би, төрөлх нутгийнхаа босгон дээр, эцэг өвгөдийнхээ эрт дээр үеэс боловсруулж ажиллаж ирсэн тариан талбайгаа манаад зогсож байгаа орос цэргүүдийг харж байна. Ээж, авгай нар нь дотор нь мөргөн залбирч байгаа — тийм шүү, бүгдээрээ мөргөн залбирдаг цаг үе байдаг юм чинь — орон байшингаа хамгаалж байгаа тэднийг би харж байна... Тун сая арваад улсыг номхруулж, гар хөлөөр нь хүлсэн, өдгөө давируулаа хавируулсан дэгжин маягийн прусс офицертой нацистын цэргийн бузар машин саяны дурдсан бүхнийг яаж нөмрөн ирж байгааг би харж байна. Царцааны нүүдэл лүгээ адил нүүгэлтсэн, хүннүгийн догшин цэргийн сургуультай, дуулгавартай бөөн саарал амьтсыг би харж байна. Амархан, баараггүй олз оллоо гэж өөрснөө санаад баярлалдан буй германы бөмбөгдөгч, сөнөөгч онгоцуудыг би тэнгэрт харж байна.

Энэ бүх шуугиан, пижигнээний цаана гай гамшгийн уруйг төлөвлөж, зохион байгуулж, түүгээрээ хүн төрөлхтнийг нэрвэж буй цөөн хэдхэн увайгүй хорлогчин байгааг би харж байна.

Бид ганц хоног ч хойш тавилгүйгээр үгээ шууд хэлэх ёстой. Бид Гитлерийг болон нацист дэглэмийн бүх ул мөрийг устгах шийдвэр төгс байна. Биднийг үүнээс юу ч няцааж чадахгүй, юу ч. Бид Гитлер буюу түүний бүүр бүлгийн хэн нэгэнтэй хэзээ ч яриа хэлэлцээ хийхгүй. Бид Бурханы тусламжтайгаар газар дэлхийгээ түүний сүүдрээс ангижруултлаа, улс түмнийг түүний тахлаас чөлөөлтлөө түүнтэй газарт ч, далайд ч, тэнгэрт ч тулалдах болно. Гитлертэй нэг байгаа аливаа хүн буюу улс манай дайсан мөн. Нацизмын эсрэг тэмцэж байгаа аливаа хүн буюу улс бидний тусламжийг авна.

Орос хүн болгоны үйл хэрэг бол дэлхийн өнцөг булан бүрт байгаа эрх чөлөөт хүмүүс, эрх чөлөөт улс түмний үйл хэрэг мөн. Өөрсдийн хүч чармайлтыг бүтэн хувь дахин нэмэгдүүлье, хүч тамир, амь насныхаа хүрэлцэх хэмжээгээр хамтран тэмцэцгээ”.

Америкийн Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Рузвельт Зөвлөлт Холбоот Улсыг дэмжиж байгаагаа хоёр хоногийн дараа мэдэгдэв.

Литвиновын хэрэг гарлаа. тэрээр түүний амь насыг хэлтрүүлсэн нь зөв болж.

Одоо ингээд Литвинов түүний өмнө сууж байна. Поскребышев цай, жигнэмэг авчрав. Бас нэг жижгэвтэр дугтуй авчраад царны хажууд тавив.

– Энэ чинь юу юм?

– Ленинградаас яаралтай ирүүлсэн юм, нөхөр Ждановоос.

– Юу нь яаралтай юм?

– Мэдэхгүй. “Нээж болохгүй, нөхөр Сталинд өөрт нь биечлэн гардуулах.” гэж бичээстэй байна.

– За, би харна аа. Дараа.

Сталин арынхаа өрөөнд орж шил коньяк авчраад, цай руугаа жаахан хийснээ, бас нимбэг шахаад, түүнд хийх эсэхийг Литвиновоос харцаараа асуув. Литвинов талархал илэрхийлэн татгалзав. Сталин аанай л яаралгүй лонхоо бөглөж, буцааж аваачаад, эргэж ирж суугаад, шилэн аягандахаа халбагаар хутгаж нэг балгаад, Литвинов руу харав. Өтөлсөн байна, үс нь бууралтсан байна, гэхдээ бие нь чийрэг, нүсэр хэвээр, харцнаас нь сайшаал, муушаалын аль нь ч мэдэгдэхгүй, шилнийхээ цаана дөлгөөн хэвээр. Хуучин нөхдөөс нь, залуу цагийн анд нараас нь, чухамдаа, ганц энэ нь үлдсэн байна, ТҮҮНТЭЙ ойр байсан хүмүүс ч, Литвиновтой ойр байсан хүмүүс ч бүгд тонилжээ. Энэ Литвинов ч өөрөө, мэдээж, баривчлагдахаа өдөр болгон хүлээж байсан. Тэгсэн хэрнээ түүнд нэг ч удаа хандаагүй. Гагцхүү эхнэртэйгээ цуурна, Молотовын хаягаар хэлж байгаа мэт ухаантай цуурна, егзөр нууц ажилтан, хашир толгой.

– Гитлер эхлээд Франц руу довтолсон, энэ бол үнэн хэмээн Сталин санаандгүй эхлэв. – Гэтэл яагаад довтолов? Яагаад гэвэл бидэнтэй үл довтолцох гэрээ байгуулсан. Бид гэрээнд гарын үсэг зураагүй бол Гитлер Зөвлөлт Холбоот Улс руу биднийг дайнд бэлэнгүй байхад, аль ноднин довтолох байсан. Одоо бол эзлэгдсэн Европт хэдэн арван дивизээ арга буюу барьж байна, ноднин бол бүх хүчээрээ дайрах байсан. Тэгсэн бол хэдийнэ Москвад ирчих байсан. Тэгсэн бол чи бид хоёр энд цай уусан шиг ингээд сууж байхгүй байсан. Гитлер ноднин бүх хүчээрээ дайрсан бол, зүгээр ч үгүй, Франц, Английн уухайн дор дайрсан бол чи бид хоёр энд цай ууж байх байсан уу, чи юу гэж бодож байна?

тэрээр Литвинов руу зэвүүн харж байв. Юу гэж хариулах бол? Маргаад эхлэх үү? Үгүй ээ, маргахгүй. Дипломат хүн.

– Бид, мэдээж, энд цай ууж суухгүй байсан гэж Литвинов хариулав.

Сталин өөр тийш харж, цайгаа дахин хутгаж, нэг балгаад дахин ярьж эхлэв:

– Гитлер Смоленск хүртэл яваад тамирдчихлаа. Ленинград, Одессийн дэргэд дэвхцэж байна, тэнд удаан дэвхцэнэ. Цахилгаан дайн баларсан, энэ бол бүх дэлхийд тодорхой байгаа. Одоо Черчилль, Рузвельт хоёроос гоё үг биш, бодитой тусламж хэрэгтэй. Би Черчиллийн: “Большеvizмыг багалзуурдан устгах явдал бол хүн төрөлхтний гол буян” гэж байсныг санаж байна. Энэ түүний үг үү?

– Тийм. Гэхдээ түүний хувьд фашизм нэгдүгээр зэргийн дайсан. Тэгээд ч тэр чинь Германтай байлдаж байгаа. Зөвлөлт Холбоот Улсад тусламж үзүүлэх явдал түүний хувьд маргаангүй асуудал.

– Бодит тусламж бол хоёрдугаар фронт гэж Сталин өгүүлэв.

– Америкийг дайнд оролцохоос нааш Черчилль хоёрдугаар фронт нээхгүй.

– Черчилль бидэнд тэрслэх юм биш биз?

– Тэр, мэдээж, Зөвлөлт Холбоот Улс ялахаас айж байгаа, гэхдээ энэ бол түүний төсөөллөөр их алсын хэрэг. Одоо бол түүнд Гитлерийн ялагдал хэрэгтэй.

Сталин цайгаа гүйцээж уугаад аягаа зайчилж тавив.

– Тэгвэл Рузвельт гэдэг чинь юу юм бэ?

– Рузвельт... Шашин, ёс жудаг, зан суртахуун гэх мэтийн юмс. Гэхдээ түүний Гитлерийг үзэх үзэл тодорхой. Тийм учраас түүнд найдаж болно. Америк ойрын үед дайнд оролцоно. Америк Германы Европт ноёрхох, Японы Азид ноёрхохыг зөвшөөрөхгүй.

– Черчилль, Рузвельт... Зүтгэлтэн хүний хувьд хэн нь хүчтэй вэ?

– Рузвельт арай зөөлөн.

Сталин босов. Литвинов бас бослоо.

– За тийм байж, нөхөр Литвинов, амарч болоо байх, тийм үү? Одоо бол амрах цаг биш, нөхөр Литвинов, чамайг Молотовын орлогчоор томилъё. Хэрэгцээ гарвал Америк руу элчин сайдаар явна шүү.

Литвинов гарав.

Сталин хонхоо дарах гэж гараа сунгатал харц нь Ждановын дугтуй дээр туслаа. Лацадсан тамгийг нь хуу татаад дугтуйг нээв.

Дугтуй дотор германы гурван ухуулах хуудас байв. Сталин эхнийхийг нь авч үзэв. Тэгтэл гэрэл зураг дээр байгаа Яков шууд нүдэнд нь тусав.

Сталин сандал руу лагхийн суув. Ганц айж байсан юм нь тийнхүү тохиожээ. Яков олзогдчихож, түүний хүү олзлогдчихож. Германууд энэ тухай нийт зөвлөлтийн ард түмэнд, нийт Улаан Армид мэдээлж байна. Яковтой хүссэн бүхнээ хийнэ, хүссэн бүхэн дээрээ албадан гарын үсэг зуруулна. Зураг дээр Яков их хөгжилтэй байна, хоёр германтай модон дотор зугаалан, нэгнийх нь нүүр рүү харчихсан, нэг юм амтархан ярьж байна. Дор нь ингэж бичжээ:

“Энэ бол долдугаар сарын 16-нд Витебскийн орчимд бусад хэдэн мянган цэрэг, дарга нарын хамт олзлогдон бууж өгсөн Яков Жугашвили, Сталины том хүү, 14 дүгээр хуягт танкийн дивизийн 14 дүгээр их бууны хорооны батарейн дарга... Та нарыг айлгахын тулд германууд олзлогдогсодтой муухай харьцдаг гэж комиссарууд та нарт худлаа хэлдэг. Сталины өөрийнх нь хүү өөрийнхөө жишээгээр энэ худлаа гэдгийг батлаж байна. тэрээр германы армид үзүүлэх аливаа эсэргүүцэл ямар ч нэмэргүй учраас олзонд бууж өгчээ”. Ар дээр нь: “Олзны үнэмлэх. Үүнийг үзүүлэгч нь еврейчүүд, комиссаруудын ашиг сонирхлын төлөө утга учиргүй

цус асгаруулахыг үл хүсэн, германы зэвсэгт хүчний талд орж байна” гэж бичээстэй аж.

Нөгөө хуудсан дээр нэг хуаранд юм уу, цуглах цэг дээр Яковыг өөрийг нь сонирхон харж байгаа германуудын дунд шинельтэй байгаагаар авчээ. Гурав дахь хуудсан дээр Яков инээмсэглэн (инээж байна, муу золиг!) нэг юм уншиж байна, хажууд нь нэг толиотой, гоё герман офицер сууж байна.

Бас бичигтэй: “Сталины хүүгийн жишээг дагацгаа! Тэр олзонд бууж өгсөн. Тэр эсэн мэнд, бие нь гойд сайн байна. Танай жолоодогчийн хүү хүртэл олзонд бууж өгөөд байхад та нар юунд үхэл рүү очихыг хүснэ вэ? Зовсон эх орон энх амгалан болтугай! Жадаа газар хатгацгаая!”

Ар дээр нь Яков өөрийн гараар: “Хүндэт эцэг минь! Би олзонд байна, бие сайн, намайг удахгүй Германд офицеруудын аль нэг хуаранд явуулна. Сайн харьцаж байна. Энх тунх байхыг хүсье. Бүгдээрэнд нь мэнд уламжлаарай. Яков”.

Сталин хуудаснуудыг эмхэлж дугтуйд нь хийв.

Үл бүтэх золиг! “Сайн харьцаж байна” шүү... Увайгүй новш! Эцгийгээ, армия шившиг болгож, эх орныхоо ар нуруу руу шаалаа. Албадав уу? Эрүү тулгав уу? Магадгүй. Гэхдээ яагаад олзлуулж бууж өгөв? Яагаад өөрийгөө буудсангүй вэ? түүнд зэвсэг байсан! Хулчийж! Зүрх алдчихаж!

тэрээр хэзээ ч хүүдээ хайртай байгаагүй, тэр ч бүү хэл, түүнийг Москвад авчирч өгөх хүртэл барааг нь ч хараагүй явсан. Хүргэн Алеша Сванизе гэж нэг муу новш, ӨӨРИЙГ нь шарлаах гэж зориуд авчирсан... Дуу шуугүй, хүнийрхий, хөдөлж цөхнө, омог бардам юм юу ч байхгүй, гэрлээд охин гарсан нь бүтээгүй, салсан, хүнтэй буудалцсан, даанч оноогүй, тэр ч бүү хэл, одоо өөрийгөө буудъя гэсэнгүй. Заяагүй золиг, нэг муу охиноос болж, хүнтэй буудалцсан, тэгсэн чинь одоо, одоо, нэр төрийн хэрэг болчихоод байхад өөрийгөө буудахыг хүссэнгүй. Дараа нь дахиж гэрлэсэн, нөхөртөө хаягдсан нэг муу бүжигчин еврей хүүхэнтэй суусан, даруухан орос бүсгүй олох нь яана аа? Эцгийнх нь нэр хүндээс банзал илүү болж гэнэ. Заяагүй золиг! Төрсөн хүү нь олзлуулж бууж өгчээ. “Сайн харьцаж байна” гэнэ! Увайгүй новш! За, хохь нь дээ, өөрт нь л муу биз. Захирагч эзний хувьд өөрийнхөө хүүхдүүдийг гэх тухайлсан ямар ч уяхан сэтгэл байх ёсгүй. Догшин Иван, Нэгдүгээр Петр энэ тэр хүүгээ алцгаасан, тэр нь ч зөв байсан.

Сталин хонхоо дараад, орж ирсэн Поскребышевец:

– Хэн, хэн хүлээж байна? гэж асуув.

Поскребышев уулзахаар хүлээж байгаа хүмүүсийн нэрсийн жагсаалтыг өмнө нь тавив.

Сталин нэрсийн ард хэнийг, ямар дарааллаар оруулахыг тэмдэглээд,

– Берияг оройн долоон цагт ирүүл гэж тушаав.

Поскребышев эзнээ хэнээс ч илүү мэдэхийн хувьд, орж байгаа хүн болгонд:

– Эзэн хөвчирчихсэн байгаа шүү гэж анхааруулж байв.

Долоон цагт Берия орж ирэв. Сталин Шапошников, Васильевский хоёртой яриагаа хараахан дуусгаагүй байсан тул, Берияд ухуулах хуудастай дугтуйг юм хэлэлгүй өгч, цаадах нь ч суугаад уншиж эхлэв. Шапошников, Васильевский хоёр ширээн дээрээс газрын зурагнуудаа эмхэлж аваад гарцгаалаа.

– Юу гэмээр байна? гэж Сталин асуув.

– Гэрэл зураг нь жинхэнэ зураг бололтой. Яковыг дуурайлгаж будаж янзалсан жүжигчин гэж арай боломгүй гэж Берия хариулав.

– Жүжигчин биш гэдгийг би ч харж байна! хэмээн Сталин дүрсхийв. – Би энэ хуудаснуудыг яагаад Ждановоос авч байна? Эдгээрийг зөвхөн Ленинградын хавиар хаясан юм уу?

– Үгүй ээ, энэ хуудаснуудыг хаа сайгүй цацсан. Бидэнд ч байгаа.

– Яагаад надад илтгээгүй юм?

– Би энэ тухай танд яаж хэлэхээ мэдэхгүй байсан юм, нөхөр Сталин.

Сталин ширээ шаав.

– Нууж байсан болох нь уу?

– Танд илтгэхээсээ өмнө ямар арга хэмжээ авч болох талаар бид бодож байсан юм.

– Тэгээд юу бодож олцгоов?

– Яков одоо хаана байгааг тодруулах хэрэгтэй. Германууд түүнийг маш нарийн хамгаалж байгаа нь гарцаагүй. Олзныхныг бөөнөөр нь шилжүүлэх үед түүнийг олоход хэцүү.

– Та нар түүнийг сарын дараа, хоёр сар, жилийн дараа олвол яах юм?

– Зохион байгуулж орлуулахыг хичээнэ.

Сталин босч, сурсан зангаараа өрөөн дотуураа алхав.

Оргуулна... Манай мянга мянган олзлогдогч оргож чадахгүй байхад Сталины хүү чадсан байх юм гэнэ. Хэн тэгж итгэх юм бэ? Ард түмэн: Сталин Гитлертэй тохироод хүүгээ аварсан байна л гэж хэлнэ. Ингэсэн хойно ард түмний нөхөр Сталинд итгэх ямар итгэл ямар болох вэ?

тэрээр Бериягийн өмнө ирж зогсов.

– Яковын хаана байгааг мэдмэгц надад илтгээрэй. Германуудыг түүний нэрийг манай арми, манай орны нэрийг хорлоход ашиглах боломжгүй болгох хэрэгтэй.

Берия босов.

– Эхнэрийг нь шоронд, ганц хүний өрөөнд хий гэж Сталин нэмж хэлэв.

– Охиныг нь?

– Светланад өгчих, яахыг тэр л шийднэ, хөгшид дээр ч аваачиж магадгүй.

50 дугаар арми Брянскийн орчимд бүтэн сар ширүүн тулалдаж, бие бүрэлдэхүүн, техникийнхээ ихээхэн хэсгийг алдаж байж бүслэлтээс Ока голын зүүн эрэг рүү Белевийн хавиар гарав. “Катюша”-гийн сум, шатахуун хоёр дууссан учраас дайсан руу сүүлчийн буудлагаа хийгээд арга буюу түүнийг устгав. Арван нэгдүгээр сарын эхээр тус арми дайсанд дахин шахагдаж ухраад, Дубна-Плавскийн зааг дээр бэхжиж авав. Ахлах дэслэгч Березовскийн командалсан авто суманд хүнд шархдагсдыг ар тал руу, фронтын нүүдлийн эмнэлэгт хүргэхийг тушаажээ.

Эдний суманд дөчин хоёр машин, удирдах бүрэлдэхүүнээс Березовский, салааны дарга Овсянников хоёр үлджээ. Березовский Сашад:

– Панкратов, та л туслахгүй бол болохгүй нь. Ахлагч, улс төрийн удирдагч, хэд хэдэн салааны дарга нар байхгүй болсныг та мэдэж байна. Би Овсянниковыг өөрийн туслахаар томилсон, тэр бүх аж ахуйн ажлыг дөнгөхгүй. Та техникийн талыг нь хариуц. Техникийн туслах ирүүлэнгүүт таныг чөлөөлнө гэв.

Сашад тэгтлээ нэг их ажил нэмэгдсэнгүй. Засварын машин бүтэн байгаа, бас Василий Акимович эсэн мэнд байгаа, юмаа мэддэг механик. Жолооч нар нь хашир, туршлагатай хэдий ч урьд нь ч Сашагаас зөвөлгөө авч байсан, одоо бол даргадаа хандаж байгаа ухааны юм болох нь. Саша цолгүй хэвээр байгаа учир түүнийг нэг бол “инженер”, нэг бол овгоор нь Панкратов гэнэ.

Машинаа байдгаар нь цэвэрлэж, сүрэл дэвсэж, чадах хэрээрээ бэржээх олж, шархтангуудыг хүлээн аваад, товлосон цэг дээр цуглаж, шатахуунаа базааж, хүнсээ хүлээж авмагц, их, бага эмч, сувилагч нар машины бүхээгээр таран сууцгаагаад замд гарлаа. Толгойн машинд Березовский, хаалтын машинд Овсянников, бөгсөнд нь Саша засварын машинтайгаа явах болов.

Гэнэт манан сууж, германы онгоц нислэг хийхгүй байсан тул авто сумангийнхан шархтангуудыг хоёр дахь хоногтоо нүүдлийн эмнэлэгт хүргэж өгөв.

Фронтын ар талынхан жижигхэн хотод байрласан болохоор дөчин хоёр машиныг германы нисэх хүчнээс нуух арга байхгүй, нэмэрт нь фронтын байгууллагууд өөр өөрийн машинтайг ч хэлэх үү. Сумангийнхан хавийн гурван тосгонд таран байрласны нэгнийх нь ахлагч Овсянников, нөгөөгийнх нь Саша, гуравдахийнх нь Гурьянов, хуучин гараашийн дарга, намын гишүүн.

Березовский хотод үлдэж, хаашаа явах, юу ачих тухай заавар хүлээх болов. түүний дэргэд бүхнийг ологч жолооч Проценко байгаа.

Бүтэн сарын хүнд тулалдаан, түүнээс үүдсэн мянган зовлонгийн дараа тосгоны тайван амьдралыг диваажин гэмээр.

Проценко тосгоныхонд тамхи, хуурай хүнс олж өгнө, тэд өөрсдөө төмс, өргөст хэмх, байцаа

энэ тэртэй. Хажуугийн ойд аль ноднингоос хэвтэж байгаа бэлтгэлийн түлээг жолооч нар айл хунараар зөөж, хурааж өгсөнд архич гараад ирдэг юм байна. Халуун усны газар ч байж байна. Амьдрал гэж шар тос. Гэвч удаан үргэлжилсэнгүй.

Проценко долоо дахь хоног дээрээ Березовскийг Сашагийн байшин руу авчирч буулгаад, өөрөө жолооч нарыг цуглуулахаар тосгоноор давхив.

– Би энд жолооч нартай ярилцаж байя, та надад ганц хоночихоор байр олоотох гэж Березовский Сашад хэлэв.

– Та хүсвэл энд хонож болно, хоёр ортой юм чинь.

Березовский малгай, шинелиэ тайлж, хаалганы хажуудах дэгээнд өлгөөд, орны ирмэг дээр сууж, тамхиа нэрэв.

– Би Овсянников, Гурьянов хоёр дээр очлоо. Тэдний машинууд бэлэн байна. Таны энд ямар байна?

– Бүгд явж байгаа.

Жолооч нар үүдэнд гутлынхаа цасыг гүвж орж ирээд, хэн ирснээ илтгэнэ. Березовский тэднийг чимээгүй харж байв.

Тэг тэгсээр бүгд цугларав.

Березовский тамхиа пяланд нухаж унтраав.

– Байгаа байгаа юман дээрээ сууцгаа. Тамхи л битгий татаарай, би бөөн утаа тавьчихлаа.

Зарим нь хананы дэргэд явган сууж, зарим нь зогссон чигээрээ үлдэв.

– Маргааш яг зургаан цагт эндээс хөдлөнө. Очих өртөөг замдаа хэлнэ. Ийшээ эргэж ирэхгүй. Асуулт байна уу?

– Дулаан хувцас яхав, нөхөр ахлах дэслэгч ээ? Өвөл, чухамдаа, хаяанд ирчихлээ гэж Байков асуув.

– Чихтэй малгай, эсгий гутал, хөвөнтэй өмд цамц энэ тэрийг очих өртөөн дээрээс авна, тэгээд тэндээ тавьж өгнө. Өөр асуулт байна уу? гэснээ Саша руу эргэж, – Танд нэмж хэлэх юм байна уу? гэхэд Саша,

– Мотор царцсан байгаа, өглөө гэхэд нэг нэг хувин халуун ус зэхвэл зүгээр сэн. За бас хүрз, сүх, чирэх татлагаа байрандаа мартуузай гэв.

– Төмөр хүрзээр шальж цэвэрлэхгүй гэж Василий Акимович эргэлзэн өгүүлэв. – Модон хүрз хэрэгтэй. Хийж ядах юмгүй: иш хийх модыг голоор нь жаахан хөрөөдөж, сарампай хавчуулаад хадчихна. Ердөө л тэр.

– Ердөө л тэр гэж Чураков түүнийг дооглоод, – Сарампай хаанаас олох болж байна? гэв.

– Надаас ирээд аваарай.

– Танд их байгаа юу? гэж Березовский асуув.

– Хоёрын зэрэг хавтан байх биз гэж Василий Акимович зувчуулсхийн хариулав.

– Бусад сумангийнханд бас нөөнө шүү. Өөр асуулт алга уу?.. Тэгвэл, дахин хэлье: яг зургаад хөдөлнө. Одоо тарцгаа. Проценко, миний юмыг ийш нь оруулчих.

Жолооч нар яваад өгөв.

Проценко нэг жижигхэн чемодан, үүргэвч, нэг боодолтой юм оруулж ирээд, боодолтой нь май загас гэж тайлбарлав.

– Баярлалаа, яв. Маргааш тавд ирж намайг аваарай.

Березовский мөрөвчөө тайлж, хуйтай гар буугаа дэрэн доогуур шургуулаад, захныхаа товчийг тайлнаа гутлаа сугалж, жийргээ задлав.

– Хатаах газар байна уу?

– Байлгүй яахав, алив нааш нь өгчих.

– Нэг мөрт буцалсан ус захьчих, цай ууцгаая.

– Халуун хоол маягийн юм яах уу? Өндөг шаруулж болж байна.

– Май загастай чинь чанасан төмс л дээр дээ, хэрэв байвал.

Саша гал тогоо руу орж, жийргийг пийшин дээр дэлгээд, ижилхэн хоёр эзэгтэй эмгэнээс ус буцалгаж, төмс чанаж өгөхийг хүсэв. Нөгөө хоёр миегнэж алдлаа. Тэд Сашад их талархаж байгаа: нэг машин түлээ буулгаж өгсөн төдийгүй, нөхөдтэйгөө хуу хөрөөдөж, хагалж өгсөн, одоо өвөлжин түлштэй, даарахын зовлон үзэхгүй.

Саша өрөөндөө эргэж ирэв.

Ширээн дээр цэмбэн гэртэй зузаан хөнгөн цагаан дашмаг байгаа нь мэдээж архи. Березовский сонин дэлгэчихсэн, дээр нь нэг том тарган май загас янзалж байна.

– Ар талынханд ямар май загас байдгийг харж байгаа биз, жинхэнэ цагч шүү дээ. Амталж явсан уу?

– Тийм явдал бий.

– Миний гар заваарчихлаа, үүргэвчнээс цөцгийн тос, талх гаргаад ир, талхыг нь аян хамтад

зүсчих.

Хоёр эмгэн шилэн аяга, халбага, сэрээ, давсалсан хэмх, дарсан байцаа, хэрчсэн сонгинотой таваг сэлт авчраад, хэсэг хугацааны дараа алчуураар бүтээсэн ширмэн бортого авчирсан нь чанасан төмс аж.

– Цадталаа идэцгээгээрэй.

Березовский дашмаг руу дохив:

– Панкратов, аягалаарай. Би уул нь гараа угаачих ёстой хүн л дээ.

Аягатайгаа авахад түүний хуруу салгалж байв.

– Эхнийхийг ялалтын төлөө уух ёстой.

Ууцгаалаа.

– Сайхан байна гээд Березовский мөрөө шилгээв.

Май загас сэрээдэн авчажилснаа, хөмсгөө сөхөв.

– Ийм юм идэлгүй их уджээ. Танд ямар байна, Панкратов? Амттай байна уу?

– Гойд гэж Саша магтав.

Березовский ширмэн бортогоны алчуурыг авахад чанасан төмсний үнэртэй уур нүүр рүү ханхийгээд явчихлаа. Хоёр тавгандаа төмс хийгээд, бортогог алчуураар буцааж хучив.

– Хөрчих вий гэж хучиж байна. Аягалаарай. Та бид хоёр хэзээ дахиж ууж таарах бол, Панкратов? Ялалтын дараа магадгүй юм. Та юу гэж бодож байна?

– түүнээс эрт ч магадгүй.

– Эрт ээ? Фронтын сүүлийн үеийн байдлыг та мэдэж байгаа юу?

– Германууд дахиад довтолж эхэлсэн.

– Тийм, тэгсэн. Манай фронт дээр Гудерианы танкийн арми байлдаж байгаа.

тэрээр хуруугаараа зовхио чимхэж, ширээ тохойлдоод, Саша руу духайн харав.

– За Панкратов анхааралтай сонсож бай. Та техникийн туслах хийж байгаа.

– Ямар юмных нь техникийн туслах байхав дээ, дэм шуу юм уу даа хэмээн Саша мушилзав.

– Хийхийн цаагуур хийж байгаа. Тэгэхээр, та техникийн туслахын хувьд зорилтоо мэдэж байх ёстой. Зорилт бол ийм байгаа. Манай суманд өвлийн хувцас, хүнс, буу зэвсэг ачиж хүргэх

үүрэг өгсөн. Бид ачаа авах ёстой завсрын өртөөг би одоо танд үзүүлье гээд Березовский цүнхнээсээ зураг гаргаж, орон дээр дэлгэв.

– Энэ бол Михайлов хот, хар.

– Тийм байна, би очиж байсан газар.

– Михайловоос урагшаа төмөр зам явж байгаа, за, энэ хэрчим: Михайлов хойд талд нь, Павелец урд талд нь. Энэ хооронд биднийг вагон хүлээж байгаа гэх завсрын өртөөнүүд байгаа. Гэхдээ... гээд мань хүн, – Михайлов хотыг Гудерианы цэрэг эзэлчихсэн, түүний хөдлөх бүрэлдэхүүн Скопинд байгаа гэж аажуухан, үгээ зөөн нухацтай өгүүлэв.

– Скопинд оо?

– Мэдээллийн товчооны тоймонд тийм мэдээ байхгүй, гэхдээ миний буусан айлын эзэн Скопин руу утасдсан чинь, залгагч хүүхэн: “Манай энд германууд байгаа... Архидацгааж байна... Улс амьтны дулаан хувцсыг булааж авч байна...” гэж хэлсэн. Гэтэл манай ар талын штаб энэ тухай мэдэхгүй байгаа. Нөгөө магтаад байсан цэргийн тагнуулын алба чинь энэ дээ. Бидний хувьд энэ ямар учир холбогдолтой вэ? Ийм учир холбогдолтой: германууд Скопин руу зөвхөн Павелецээр дамжиж очсон байх ёстой. Тэгэхээр Павелец бас эзлэгдсэн гэсэн үг. Тийм учраас Михайлов, Павелец хоёрыг холбосон төмөр зам германы гарт байх нь. Бид хаанаас ачаагаа авах вэ?

– Бид яах гэж тийшээ явж байгаа юм? гэж Саша асуув.

– Би ч тийм асуулт штабынханд тавьсан. Тэд нар: “Скопинд германууд байхгүй, бэртэгчний зохиомол яриа. Михайловт германы мотоциклчид ирснийг хөөгөөд буцаасан. Тийм учраас явцгаа, юмаа ачаалцгаа” гэж хэлсэн. Лут байгаа биз! Яваад хүрчихлээ, юмаа аччихлаа гэж саная. Тэгээд хаашаа явах ёстой гээч? Узловая өртөөний ойролцоо Хоёр зуун гучин есдүгээр буудлагын дивизийн байршил руу. Энэ хаа байдгийг нь хар даа гээд зураг дээр зааж үзүүлэв. – Харав уу? Хойд талд! Гэтэл Гудериан Михайлов орчихсон юм бол Узловая таслуулсан гэсэн үг. Бид тийшээ яаж нэвтрэх вэ? Агаараар уу? Штабынхан: “Узловая таслагдаагүй, бид тэдэнтэй холбоотой байгаа. Командлалын тушаалыг биелүүлцгээ” гэж хэлсэн. Ийм тушаал юунаас болж өгч байна? Тэгвэл ийм юмнаас болж...

тэрээр дэнгээс тамхиа асаагаад үргэлжлүүлэв:

– Хоёр зуун гучин есдүгээр дивизийг Тавьдугаар армид шилжүүлсэн. Энэ дивизийг дулаан хувцас бас бус юмаар хангах хэрэгтэй. Үүнийг яаж хийх вэ? Яах юу байхав, маш амархан. Манай авто суман бас Тавьдугаар армиас ирсэн, бид тийшээ л буцах ёстой. Тэгэхээр буцацгаа. Харин замдаа Хоёр зуун гучин есдүгээр дивизийн ачааг аваад яваарай. Тэд нар ингээд бидний ард нуугдчихаж байгаа юм. Юм болвол баримт бичгээ үзүүлчихнэ: тэддүгээр авто суманг явуулсан... Тэддүгээр цуваа руу... Вагоны дугаар нь энэ... Дагалдангийн дугаар нь энэ... Цаад учрыг нь хэн ч олохгүй. Бүгдийг нь явуулсан, бүгдийг нь илгээсэн... Харин хүрээгүйн тухайд бол, уучлаарай, дайн... Гэхдээ бид тушаал биелүүлсэн. Ийм л байна даа, Панкратов. Ганц дөнгөсөн юм гэвэл, тэр муусайнаас тав хоногийн хүнс, машин болгонд

гурван удаа цэнэглэх бензин салгалаа, сувилагч хүүхэн бас гаргаж өгсөн, түүнийг би Овсянниковт үлдээсэн, цаадах чинь, чи мэднэ ээ гайгүй, нялх амьтан. Сумангийн хэмжээнд хорин винтов өгсөн. Брянскийн хавьд хоосон гараараа үзэлцэж байсан бол одоо зэвсэгтэй болсон, гурван хүн тутмын нэг нь 1891-1930 оны хийцийн винтовтой. Бүхнийг ялна!

Березовский зургаа цүнхэндээ хийж, архинаасаа хийгээд, Сашаг хүлээлгүй уучихав.

– Ажил явдал ийм байна, Панкратов! Манайхны тоо аль хэзээний сая саяар тоологдож байгаа, нийт улсын хэмжээнд тавьхан хүн чинь юу юм бэ? гээд Березовский нүдээ онийн Саша руу харав. – Одоо хүмүүс ийм болчихоод байна, Панкратов оо. Нөгөө хүмүүс байхгүй болсон. Нөгөө хүмүүсийн тухай шүлэг л үлдэж...

тэрээр зовхио барьж байгаад бүдэг дуугаар ийн уншив:

Аймшиггүй дайчид улайран довтолж,

Адаг сүүлдээ хайлсан тугалга

Аргагүйн эрхэнд яаж залгиж асныг

Аанай, хоёр циймрээрээ харсаан.

– Хэний шүлэг гэдгийг та мэдэх үү?

– Уткиных. “Есениний үхэлд”.

– Тийм, Уткиных... За тэгвэл, Панкратов, би тэр аймшиггүй хүмүүстэй чинь мөр зэрэгцэн байлдаж явлаа, одоо тэд байхгүй. Харин нөгөөдүүлийг байхад, Деникин, Колчак, Юденич, Врангель, чехословакууд, Украинд германууд, Одесст францууд, Архангельскт англичууд, Алс Дорнодод японууд гутал хувцасгүй, өлөн зэлмэн, зэр зэвсэггүй Улаан Армийг дийлж дөнгөөгүй юм! Тэгвэл одоо ганц Германтай байлдаж байна, гэтэл германууд бүр Москвагийн хаяанд ирчихээд байна. Та Панаит Истрати гэдэг зохиолчийг мэдэх үү?

– “Кира Киралина”-г уншиж байсан.

– Сайн зохиолч, балкан нутгийн Горький. Тэгвэл тэр чинь нөгөөдүүлийн тухай: “Оросын хувьсгалын алтан сан” гэж хэлсэн юм. Одоо тэр алтан сан хаана байна? Эднүүс тэдний халааг аваад байна. Дээрээсээ доороо хүртэл. Тэгээд л Оросыг идшинд барьж өглөө, тэгээд л хүмүүсийг үхэл рүү хөөж тууж байна.

Панаит Истрати “Оросын хувьсгалын алтан сан” гэж хориод онд Сталины эсрэг тэмцэж байгаад, гучаад онд устгуулсан сөрөг хүчнийхнийг хэлснийг Саша санаж байгаа билээ.

– Нөхөр ахлах дэслэгч, таныг харахад цэргээр дагнасан хүн шиг байх юм. Та яагаад ийм бага цолтой байгаа юм?

Березовский өөртөө төмс нэмж хийгээд, цөцгийн тос түрхэв.

– Хөрчихөөгүй байгаа дээр нь ид. Орос зууханд ширмэн бортогонд чанасан төмс, Москвад хийн зуухан дээр чанасан төмснөөс шал өөр амттай байдгийг та анзаарсан уу, Панкратов? Та чинь Москвагийн хүн биз дээ?

Саша инээв.

– Би Москвагийнх, гэхдээ аль төмс нь амттайг мэдэхгүй.

– Москвагаас гараад их удсан уу? гэж Березовский санаанд оромгүй асуув.

– Их удсан гэж Саша товчхон хариулав.

– Би яг тэгж бодсон юм гэж Березовский өгүүлэв. – Тэгэхээр, таны асуултад хариулья. Би иргэний дайнд байлдаж явсан, арван есөн оноос намын гишүүн. Одоо бол музейн ховор үзмэр гэсэн үг. Ном үзсэн, инженер болсон, Горькийн автомашины үйлдвэрт ажиллаж байлаа. Давган шалгалтаар, сумангийн бэлтгэл даргын хувьд ахлах дэслэгч цол авсан, тэгээд л тэр цолтойгоо үлдсэн юм гээд мань хүн босов. – За, Панкратов, хажуулцгаая, маргааш эрт хөдөлнө. Хүмүүсээ эцсийн, шийдвэрлэх тулалдаанд хөтлөн оруулна... Би түрүүлээд яваад өгнө, Фофаново тосгонд, Овсянников дээр уулзацгаана.

Аравдугаар сарын 2-нд Сталины ширээн дээр Гитлерийн тушаалыг тавив: “Эцсийн бүлэгт өнөөдөр сүүлчийн маш том цохилт хийх урьдчилсан нөхцөл бүрэлдлээ. Энэ бол өвлөөс өмнө дайсныг устгах цохилт болох ёстой. Хүний хүчрэн хийж болох бүх бэлтгэл дууслаа. Өнөөдөр энэ оны сүүлчийн шийдвэрлэх тулалдаан эхэлж байна.”

Орост төвлөрсөн Германы бүх армийн тэн хагас нь Москва руу хөдлөв. Энэ ажилбар “Хар салхи” гэдэг нууц нэрээр явж байгаа аж. Аравдугаар сарын 3-нд, Орёл, 6-нд Брянск, 7-нд Вязьма тус тус унаж, тэнд зургаан буман цэрэг, дарга нар бүслэгдсэн нь есдүгээр сард Киевийн орчимд олзлогдогсдын тоотой бараг дүйж байлаа.

Сталины дуудлагаар аравдугаар сарын 7-нд Жуков Москвад нисч ирэв. тэрээр Ельнийн ажилбарыг амжилттай хэрэгжүүлснийхээ дараа Ленинградын хамгаалалтыг зохион байгуулж, дайсныг хотод оруулсангүй. Одоо Баруун фронтыг тэргүүлэн Москваг хамгаалах ёстой болж.

Нойргүйдээ улаан нүдэлж, царай алдсан Жуков онгоцны буудлаас Сталины гэр рүү шууд очив. Сталин салхинд цохиулаад, бас царай нь гойдгүй харагдана. Ажлынх нь өрөөнд Молотов, Берия хоёр сууж байв. Сталин Жуковт толгойгоороо дохин сандал заав.

– Германууд ойрын үед Ленинград руу дахин довтолж чадах уу?

– Чадахгүй гэж бодож байна. Тэд хамгаалалтынхаа урд биеийг бэхжүүлж байгаа. Танкийн болон моторжуулсан цэргээ шилжүүлсэн, Москвагийн чиглэлд л болж таарах нь.

– Баруун фронтын командлалыг хүлээж ав, учир байдлыг тодорхой олоод, над руу утасдаарай.

Жуков явлаа.

Сталин босч, өрөөн дотуураа хэд алхсанаа, Молотов, Берия хоёрын өмнө очиж зогсоод тэдэн рүү харав.

– Дайсан Москвагийн босгонд тулаад ирчихлээ, гэтэл бидэнд хотоо хамгаалах хүрэлцээтэй хүч алга. Кутузов Москваг орхиж байгаад дайнд ялалт байгуулсан. Гитлер дөрвөн сар байлдаж байгаа хэрнээ Москва, Ленинград, Донбассын алийг ч авч чадаагүй байна. Гэтэл мэд өвөл болно. Оросын өвөл! Германууд муусайн шинель, даавуу малгайтайгаа яаж байлдах юм бол? Гитлер дайныг зогсоож, нэгэнт эзэлсэн юмаа авахыг илүүд үзэхгүй юү? Балтийн улсууд, Белорусс, Украины нэг хэсэг, аргаа барвал бүх Украиныг авахыг илүүд үзэхгүй юү? Салангад энх тайвны гэрээ байгуулах уу? Тийм ээ, салангад энх тайвны гэрээ. Ленин 1918 онд германуудтай салангад энх тайвны гэрээ байгуулахаас айгаагүй. Бид тийм гэрээ байгуулахаас яагаад айх ёстой билээ? Ленин Брестийн энх тайвны гэрээг түр зуурынх гэж үзэж байсан, тэгээд алдаагүй: германы империализм сөнөх тавилантай байсан. Германы фашизм сөнөх тавилантайг бид бас ойлгож байна, тэгэхээр одоо өгөх юмаа бид ч буцаагаад авчихна. Өөрсдийнхөө шугамаар Гитлерт энх тайвны гэрээ байгуулах санал нэн даруй тавих боломж олцгоо.

Энэ саналыг Болгарын элчин сайд Стаменовоор дамжуулан германы засгийн газарт тавьжээ. Гитлер Москваг авна гэж эргэлзэхгүй байсан учраас тэр саналд тоож хариу өгсөнгүй. тэрээр дайны эхэнд: “Хотыг нэг ч цэрэг, нэг ч оршин суугч тэндээс гарч чадахааргүй бүслэх ёстой. Москва, түүний ойр хавийг тусгай байгууламж хэрэглэн усанд авахуулахаар шаардлагатай бүх бэлтгэлийг хангана. Өнөөдөр Москва байгаа газар дээр оросын ард түмний нийслэлийг иргэншсэн ертөнцөөс үүрд нуух асар том тэнгис бий болох ёстой” гэж тушаал буулгажээ. Одоо тийм байгууламж барих цаг байхгүй учраас ерөнхий командлалын удирдамжинд: “Фюрер Москва бууж өгвөл бид зөвшөөрөх ёсгүй гэж дахин шийдсэн. Эзлэн авахын өмнө их бууны гал, агаарын довтолгоогоор ниргэж, хүн амыг нь дүрвүүлвэл зохино. Хичнээн олон хүн ам Оросынхоо дотогш зугтана, төдийчинөө эмх замбараагүй байдал даамжрана” гэж заасан байв.

Германууд аравдугаар сарын 13-нд Калугаг, 14-нд Калининг, 18-нд Можайск, Малоярославецийг тус тус эзэлж авав. Гэтэл Можайскийг унахаас хоёр өдрийн өмнө германы мотоциклчдыг хотын захад, Волоколамскийн засмал дээр харсан гэх цуурхал Москвагаар тарж эхэлжээ. Байгууллагууд архиваа шатаацгаалаа. Засгийн газрын байгууллагуудыг бөөн бөөнөөр нүүлгэн шилжүүлэх ажил эхэлж, галт тэрэгний буудлууд цагийн хуваариа өөрчиллөө. Куйбышевт нөхөр Сталинд зориулсан газар доор цооногон байр барьж эхлэв. ДЯАК-ын төв аппаратынхан мөн тийшээ нүүн шилжихийн хамт мөрдлөгт байгаа хамгийн чухал хүмүүсийг авч явсан аж. Гэвч вагон хүрэлцээгүй байсан учир Лубянскийн газар давхарт гурван зуугаад цэргийн дээд тушаалын дарга нар үлдсэнийг буудан алсан байна. түүнээс хойхно, аравдугаар сарын 28-нд түрүүн Куйбышевт аваачсан Локтионов, Рычагов, Штерн, Смушкевич, Савченко нарын генералыг буудан алжээ. Фронт дээр энэ үед хороог дэслэгч цолтой хүмүүс командалж байлаа.

Аравдугаар сарын сүүл рүү германуудыг зогсоолоо. Арван нэгдүгээр сарын 7-нд Улаан талбай дээр цэргийн парад хийж, тэндээс фронт руу явж байгаа дайчдад хандан Сталин үг хэлэв. Москва руу германы онгоц дайрч ирж мэдэх байсныг бодолцвол, ингэж индэрт гарсан нь дайны туршид түүний хийсэн цорын ганц зоригтой үйлдэл байсан юм.

Арван нэгдүгээр сарын дундуур сүрхий хүйтэрч, хасах долоогоос арван хэм хүрч жаварлах болов. Гэвч дахин нэгэнтээ чармайж, эцсийн дайралтаар Москваг эзэлж авахыг Берлин тушаажээ, ердөө 50-60-хан километр үлдээд байсан хэрэг.

Березовский өглөөний таван цагт Проценкотой яваад өгөв. Саша машинаа асааж халаагаад, гэрийн эзэгтэй нартай салах ёс хийж, машинаараа гудамж руу гарав. Өчигдрийн цас хүйтэрсний улмаас дагтаршин царцаж, зарим газраа харлан, зам сайхан хатуурчээ.

Айлуудын хашаанаас машинууд гарч ирцгээж, Саша машин болгон дээр очиж бүрэн бүтэн эсэхийг нь лавлав. Чураков, мэдээж, модон хүрз юу гэж хийхэв.

– Хаашаа явах болж байна? гэж Байков асуув.

– Фофаново тосгон руу.

– Тэрнээс цааш?

– Би мэдэхгүй. Сумангийн дарга зарлана.

– Герман ийшээ ирж явааг чи мэдэх үү?

– Сумангийн дарга чамд бүх зүйлийг хэлж өгнө.

Березовскийн мэдээ үнэн болж таарав.

Арван нэгдүгээр сарын 18-нд генерал Гудерианы танкийн арми зөвлөлтийн цэргийн хамгаалалтыг Тула хотоос өмнүүр сэт цохиод, түүнийг тойрон хойшилж Москвагийн зүг довтолж эхлэв. Намаг балчиг, нуур цөөрөм, гол горхи хөлдөж, хавийн газраар явах боломжтой болсон нь германы цэргийн хөдөлгөөнийг хөнгөвчилжээ. Арван нэгдүгээр сарын 24-нд Гудерианы механикжсан дивиз Михайловыг эзэлж, толгойн отрядууд нь Скопин хүрчээ. Михайлов, Скопин хоёрын дундах бага шиг нутаг дээгүүр дайсны тагнуулууд, тэдний харуул хамгаалалтын бүлгүүд хэрэн давхилдаж байж.

Авто сумангийнхны дөхөж очсон жижигхэн өртөөг германууд бөмбөгдөөд дэр моднууд оглорчихсон, зам төмөр мурчилдчихсан, шатсан, түлэнхий вагонууд хөглөрч байв. Өртөөний дарга, тэдгээрийг хоосон байсан, ямар ч ачаа бараа ирээгүй, ер нь арван нэгдүгээр сарын 24-нөөс хойш Михайловоос нэг ч галт тэрэг гараагүй, тийм болохоор бусад өртөөн дээр ч гэсэн ачаа байх нь юу л бол гэжээ. Германууд нэгэнт Михайловт ирчихсэн болохоор одоо Узловая орох ямар ч арга байхгүй.

Березовский бодлоо. Даалгавар биелэшгүй нь тодорхой. Урагшлана гэдэг бол хүмүүсийг гарцаагүй үхэлд хүргэнэ гэсэн үг. Тушаал биелүүлэхгүй буцна гэдэг бол өөрөө цэргийн шүүхэд очно гэсэн үг, гэхдээ хүмүүс амьд үлдэнэ, тэд нар түүний шийдвэрт захирагдсан юм чинь буруудахгүй. Буцах хэрэгтэй.

– Ойр хавийн тосгонуудаар герман байхгүй юм шиг байна, гэхдээ тэдний онгоц бол нисч байгаа гэж өртөөний дарга нэмж хэлэв.

Тэгтэл түүний үгийг нотлох мэт агаарт германы тагнуулын онгоц үзэгдсэнээ дээгүүр нь маш намхан нисээд далд оров. Нисэгч нь засмал дээр байгаа машины цувааг анзаарсан нь мэдээж, одоо баахан онгоц ирж бөмбөгдөнө дөө...

Төмөр замын нөгөө талд хагас километр алдын газарт ой харагдана. Төмөр замын гарцыг бушуухан гарч, ой руу ороод, тийшээ орох зам дээр баахан мод хөндөлсүүлэн хаялж, машинуудаа мөчрөөр хучив. Чухам яг амжиж. Өртөөний дээгүүр германы хоёр онгоц гарч ирж эргэлдэж байгаад, бөмбөгдөх бай эс олсон учир нисэн одов...

Хагас цагийн дараа машины чимээ гарч, мотоцикл тачигнах сонсогдоо. Березовский модны араар нуугдаж гэтсээр зам руу дөхөв. Тэр зам дээр гурван хуягт, автомат буутай таван мотоциклчин харагдаж. Тэд нар төмөр зам руу очиж, буудлын шовгорт орсноо төдөлгүй тэндээс өртөөний даргын хамт гарч, түүнийг мотоциклийнхээ шаахайд суулган Павелецийн зүг явцгаав.

Тэгэхээр германууд энэ замыг ч бас эзэгнэчихэж, ийшээ буцаж ирэлтгүй. Суман ойн зөрөг замаар урагшлав. Замын төгсгөлд ирээд засмал руу шууд гарсангүй. Березовский завсрын өртөө рүү тагнуул хийлгэхээр хэдэн хүн явуулав. Тагнуулчид орой эргэж ирээд, тэнд герман алга, вагон ч бас алга гэж мэдэгдэв.

Цас орж эхэллээ, ойгоос гарах хэрэгтэй. Сумангийнхан шөнө бүдгэрүүлсэн гэрэлтэйгээр Хитрованщина тосгон руу хөдлөв. Тэндээс Узловая орох зам бий. Нэг бяцхан төгөлд байрлаж, өөрсдийгөө далдалцгаав.

Березовский Руслан Стрельцовын машинд сууж тосгон руу яваад, удалгүй хоёр бидон халуун байцааны шөлтэй буцаж ирлээ.

– Ногоотой шөлийг халуун дээр нь аягалж өг, Руслан бидоныг нь авсан газраа хүргэж өгөөрэй гэж Березовский шийдвэр өгөөд, модны зах руу харуул тавьж, засварын машин руу, Василий Акимович руу Овсянников, Саша, Гурьянов гурвыг дуудуулав.

Березовский газрын зургаа дэлгээд:

– Буцах зам байхгүй. Узловая, Михайлов хоёрт германууд байгаа. Тэгэхээр, хойшоо юм уу, урагшаа бид явж чадахгүй, баруун тийшээ бол бүр ч ярилтгүй. Яацгаах вэ?

– Зүүн зүг л үлдэж байна гэж Саша хэлэв.

– Төмөр зам хүрье. Тэгээд яах вэ? Зургийг харж байна уу? Зүүн тийшээ зөвхөн Михайловоос замтай, гэтэл тэнд германууд байж байгаа.

– Өөр нэг зам бий гэж Саша өгүүлэв. – Энэ завсрын өртөө байна, энэ бол Грязное тосгон. Дайны өмнө ийш нь Пронскоос зам тавьж байгаад дуусаагүй, даланг нь дагтаршуулчихсан юм даг, тэгээд зураг дээр байхгүй байна.

– Тэр дагтаршуулсан замаар чинь машин явдаг юм уу?

– Тэрийг би мэдэхгүй.

Моторын дуу гарав. Овсянников үүдээр шагайж хараад,

– Стрельцов бидон хүргэхээр явж байна гэв.

– Тэр замаар чинь явахгүй байгаа бол цасанд дарагдчихсан байгаа, бид яаж олохов? гэж Березовский асуув.

– Километр тэмдэглэсэн шонгууд байх ёстой. Энэ замын тухай мэдэхгүй тосгон байхгүй. Зөндөөн элс, хайрга, чулуу аваачиж байсан, энд тэндгүй овоолоостой байгаа, тийм юм ч тэмдэг болно. Цас уу? Бидэнд хүрз байгаа шүү дээ.

Березовский зурган дээр зайг хэмжив.

– Дал орчим километр байх юм байна.

– Хоёр цагийн явдал гэж Овсянников хэлэв.

– Энэ нөхцөлд бол хоёр цаг биш, хоёр шөнө гэж Березовский зөрөв.

Проценко орж ирэв.

– Нөхөр ахлах дэслэгч, энд нэг ахмад хэдэн дайчинтай явж байна.

– Гүйгээд яв! Винтовтой хүмүүсээ бүгдийг нь нааш нь дууд!

Засварын машины хавьд нэг ахмад, дөрвөн цэрэгтэй зогсож байв. Бүгд автомат буутай, үстэй малгай, оготор нэхий дээл, эсгий гуталтай.

– Бичиг баримтаа үзүүлнэ үү гэж Березовский шаардав.

Ахмад энгэрээ яран, бичиг баримтаа гаргаж Березовскийд өгөөд, хавьд нь байгаа жолооч нарыг болгоомжилсон харцаар тойруулан харав.

– Дайчид машины бүхээгт орж дулаацаг хэмээн Березовский бичиг баримтыг нь буцааж өгөх зуур хэлээд, – Нөхөр ахмад, та засварын битүү машинд орно уу гэв.

– Манай авто суман Хоёр зуун гучин есдүгээр дивизийн мэдэлд очихоор явж байна, та хаашаа явж байна? гэж Березовский асуув.

– Хоёр зуун гучин есдүгээр дивизэд та нар очиж чадахгүй гээд ахмад зүүн хөлийнхөө гутлыг тайлж, жийргээ задлан оймсоо тайлаад хөлөө шалгаж үзэв. Холгосон газар хайсан байх. – Хоёр зуун гучин есдүгээр дивиз бүслэгдсэн, Тавьдугаар арми тасдуулсан. Хойно байгаа бүх юм таслагдсан.

– Та нар энд яаж ирж таарав?

– Ангиасаа тасарчихсан. Өмнө зүг рүү явж байна.

– Яагаад өмнө зүгт билээ?

– Хойд зүг таслагдсан гэж би танд хэлээд байна шүү дээ гэж ахмад адган өгүүлэв. – Герман зүүн зүг рүү давшиж байна, тэгэхээр бидэнд ганц өмнө зүг үлдэж байна.

– Тэгвэл бидэнд юу гэж зөвлөмөөр байна?

– Та нарт уу? хэмээн ахмад дал мөрөө хавчив. – Та нар машинтай хаашаа ч нэвгэрч чадахгүй.

– Машинаа хаях хэрэг үү?

– Бүслэлтээс гарахад энэ байтугай техникийг устгадаг.

– Бид зүүн тийшээ, Пронск хот руу очих санаатай байна.

Ахмад нүүрээ үрчийлгэснээ, дахиад жийрэгтэйгээ ноцолдов.

– Замаар, зүгээр ч үгүй авто цуваагаар явж хэрхэвч болохгүй, та нарыг ганцхан цагт бөмбөгдчихнө хэмээн улам бухимдан, улам сургамжлах маягтай ярьж эхлэв. – Нөхөр ахлах дэслэгч, бүслэлтээс нэг бол байлдах чадвартай хүчирхэг анги байж байж гарна, нэг бол тав зургаан хүнтэй жижигхэн бүлэг болж, ойн зөргөөр явж гарна. Би, нөхөр ахлах дэслэгч, нэг бус удаа бүслэлтээс гарч байна, тийм учраас дайсантай нэг зүгт хөдөлнө гэдэг бол гарцаагүй үхэл гэдгийг мэднэ.

Ахмад босч, оготор дээл, малгайгаа өмсөөд ёслов.

– За нөхөд өө, амжилт хүсье, мэнд сайн яваарай!

Засварын машинаас гараад, хэдэн цэргээ дуудав. Гэтэл харуулын жолооч:

– Нөхөр ахлах дэслэгч ээ, тэнд герман Стрельцовын машиныг бөмбөгдөж байна! гэж хашгарсаар гүйж ирэв.

Цөмөөрөө ойн зах руу харайлгацгаав.

Стрельцовын машин замаар хурдалж байна. Дээгүүр нь маш ойрхон “мессершмитт” нисч өнгөрөв. Стрельцов гэнэт зогссонд бөмбөг машиных нь өмнөхөн унаж дэлбэрэв. Стрельцов тэр газрыг тойроод цааш хурдлав. Онгоц эргээд түүний өөдөөс нисэхэд, жолоочийн дуулгатай толгой нь тодхон харагдаж байв. Стрельцов энэ удаа зогссонгүй, харин хурдаа нэмэх шиг болтол бөмбөг түүний ард уналаа. Германыг дахих санаатай эргэх гэж байх хооронд Стрельцов сумангаас холгүй ой руу орчихлоо.

– А-яа-яа! гэж Овсянников дуу алдав.

Ахмад Березовскийд хандан,

– Ганц машиныг элдэж байна, гэтэл та бүтэн цуваа гаргана гэж байх юм гэв.

Тэгээд дөрвөн байлдагчаа дагуулан явж одов.

Стрельцов хүрч ирээд, машин зүв зүгээр гэж илтгэв. Березовский сумангаа жагсаагаад Стрельцовт эрэлхэг зориг гаргасных нь төлөө талархал илэрхийлэв. Дараа нь, замд гарахад бэлтгэх тушаал өгч, хөдөлгөөний журам, хоорондын зай, дохио энэ тэрийг тодорхойлоод, сумангаа тавгаар хувааж, ахлагч нарыг томилов. Өөрөө цувааны эхэнд явна, дунд нь Овсянников, хаалтанд Саша, Василий Акимович хоёр засварынхаа машинаар явна. Ганцаараа дулаан хувцастай сувилагч Тоня хөлдөхөөс сэргийлэх тос тарааж, яаж ашиглахыг хүн болгонд ихэд хичээнгүйлэн тайлбарлаж өгөв.

Тэг тэгсээр бүх юм жин тан болов.

Бүрий буусан тул Березовский Овсянниковт сүүлчийн заавраа өгөөд, Проценкогийн машинд сууж, зам руу гарснаа хэдхэн метр яваад гэнэт зогсож бүхээгнээсээ гарав.

Овсянников түүн рүү гүйж очсоноо, жолооч нар руу эргэж,

– Дугуйны нь хий гарчихаж... гэж хашгарав.

Саша, юмыг яаж мэдэхэв, тусламж хэрэгтэй болох ч юм сан уу гэж бодоод мотороо унтраав.

Гэтэл машинаас ч бууж амжсангүй.

Нүд ирмэхийн зуур бүх болж өнгөрөв. Ойн цаанаас “мессершмитт” гэнэт маш доогуур нисч ирээд пулемётоор шүршчих нь тэр.

Березовский, Овсянников хоёр ойчоод өглөө.

Березовский шинелийнх нь энгэр задгай, цэрэг цамц нь цус болчихсон гэдэргээ хараад хэвтгэж байна. Өрөөсөн гар нь цусанд хутгалдсан нүүрэн дээрээ, бас цус болсон нөгөө гар нь сул байна. Овсянниковыг бүхээгний гишгүүр дээр суулгахад тэрээр хаалгыг нь налан гулдайв. Тоня толгойг нь боох зуур нүд рүү нь байн байн харж байв.

– Тайван байгаарай, тайван, би аятайхан яана...

Березовскийн хажууд зогсож байгаа Саша руу Тоня хяламхийн, толгой сэгсрэв:

– Бүх юм өнгөрч...

Саша, Гурьянов хоёр Березовскийг өндийлгөж, Саша планшет, мөрөвчтэй гар буу хоёрыг нь мулталж, цэрэг цамцных нь халааснаас бичиг баримтыг нь гаргах зуур гэрэл зурган дээр хараа нь тусав. Усанд сэлэх хувцастай хоёр охиноо тэвэрсэн Березовский рүү нүдэнд дулаахан хүүхэн налсан зураг. Зуны өдөр, голын хөвөөний нарлах газар.

Овсянниковыг засварын машин руу, Березовскийг ой руу аваачив.

Таг харанхуй болохоос өмнө булшны нүх амжиж ухах санаатай бушуухан бушуухан гар сэлгэн, царилаар балбан, хүрзээр малтаж төнхөн яаравчлав. Юрий Иванович нүх рүү халаасны чийдэн тусгаж хараад, – Одоо болно! гэв. Засварын машинаас хоёр банз олсноо, тайрч нийлүүлж хадаад, дээр нь даргыгаа тавьж, оосорлож байгаад нүх рүүгээ аятайхан буулгаж, бэржээхээр бүтээгээд шороогоор дүүргэж, дээрээс нь хуучин дугуй тавьж, голд нь жижигхэн сарампайтай гадас хатгав. Сарампай дээрээ таван хошууны доор “Ахлах дэслэгч Березовский М. С.” гэж бичжээ.

Василий Акимович, Гурьянов хоёр эвийг нь тааруулж байгаад Сашаг хажуу тийш дуудаж,

– Чи бол техникийн туслах, ахлах тушаалтай нь болж таарч байна, даргын сүүлчийн тушаалыг мэдэгд гэв.

Жолооч нар винтовоор галлаж ёслоод, овгор шорооны хажууд чимээгүй зогсознов. Салхи шинелийн хормой дэрвэлзүүлэн, цас захан дотуур пүргэнэ.

Березовский үхлээ зөгнөж мэдээд, үхэхийнхээ өмнө хэлдгээ хэлж авах гэсэндээ өчигдөр өөртэй нь тэгж илэн далангүй ярьж байж гэж Саша гэнэт бодов.

– Даргын сүүлчийн тушаалыг уламжлая хэмээн Саша эхлэв. – Зүүн тийш, Пронск хот руу явна, бид өөр хаашаа ч нэвтэрч чадахгүй. Дайны өмнө Пронск хотоос Грязное тосгоныг хүртэл замын далан барих машин явсан, хатуу зам байгаа. Тэр хүрэх замд дулаацчих хэдэн тосгон бий. Тэгж явах шийдвэрийг дарга бидэнд өгсөн. Би зам мэдэх учраас толгойн машинд явна.

– Ахмад өмнө зүгт явсан, цэргүүд нь тэгж байна лээ гэж Байков хэлэв.

– Тийм, өмнө зүгт явсан нь үнэн, гэхдээ тэд чинь явган хүмүүс, ой модоор явсан, бидэнд бол зам хэрэгтэй гэж Саша хариулав.

– Тэгвэл зам дээгүүр чинь “мессер”-үүд нисээд байна, бид ч гэсэн явган байдлаар, ойгоор явах хэрэгтэй гэж Байков зүтгэв.

– Тэгээд машинаа германуудад орхих юм уу? гэж Халшин зэрэв.

– Машиныг чинь шатаачихаж болно, тэдний олз болохгүй. Стрельцов яваад буудуулсан, сумангийн дарга яваад алуулчихлаа. Цуваагаар нэвтэрч болно гэж үү? гэж Байков зэрэв.

– Стрельцов өдөр явсан гэж Саша өчив. – Дарга яаж алуулсныг та нар харцгаасан. Золгүй явдал. Ахмад, түүний цэргүүд үстэй малгай, нэхий дээл, эсгий гуталтай байсан, гэтэл бид даавуу малгай, шинель, савхин гуталтай. Осгочихно. Өнөөдөр арван нэгдүгээр сарын гучин, хорин хоёр хэм хүйтэн байна, маргааш арван хоёрдугаар сар гарна. Нэвтэрч гарах горьдлого байсаар байхад дөчин хоёр машин хаяхыг буруу гэж үзэж байна. Тийм учраас би явна.

– Панкратов, чи биднийг үхэл рүү чирж байна гэж Чураков хэлэв.

Гэвч бусад жолооч нарын хамт цуваа руугаа явлаа.

Проценкогийн машины радиаторыг цоолчихож. Гагнах цаг алга, шинэ радиатор байхгүй. Проценко Сашатай цуг явахаар новш юмханаа түүний машин руу авчрав.

Хэцүүхэн байсан хэдий ч, долоон километрийг цас ухалгүй туулж, ойгоос гарцгаалаа. Утасны шонгоор зам баримжаалж, цасан шуурга тавьж байгаа ч явахад арай амар болов.

Проценко үүргээ ухаж үстэй малгай гаргаж өмсөөд, даавуу малгайгаа уут руугаа хийчихэв.

– Хаанаас олоов?

– Хотод, эмнэлгийн дэргэдээс худалдаж авсан юм, надад бас нэг бий, чи авах уу?

Мэдээж худлаа. Хувцас хунарын агуулахаас л гуйж гувшиж аваа л даа.

– Надад хэрэггүй, Овсянниковт өгчих, харин тосгонд очихоор хүн амьтантай яриарай, хэдэн хуучин малгай олдож мэдэх юм гэж Саша хэлэв.

Бүхээгний арын шилийг цас шавчихаад арагшаа ямар ч хараа алга. Саша Проценког жолоон дээр суулгаад, өөрөө бүхээгний хаалгыг онгойлгон, гишгүүр дээр зогсоод арагшаа харав. Шуурган дундуур машины гэрэл бүүдийж, тавын зэрэг машин явж байгаа юм уу гэлтэй, цаашаа учрыг олохын арга алга, зогсож болохгүй, зам гаргаж явах хэрэгтэй.

– Хаалгаа хаа, бүхээгт хүйтэн орчих нь гэж Проценко хашгарав.

Тэр ч үнэн шүү. Гэвч Саша байн байн хаалга нээж арагшаа харсаар явав. Цас улам өтгөрч, шуурганы хүч нэмэгдэж байвч, утасгүй ч гэсэн шонгийн мод зам заасаар байв.

Хоёр цаг өнгөрч байхад нэг завсрын өртөөн дээр ирцгээв. Тэнд юу ч алга. Нэг ч гэрэл гэгээ, нэг ч орон байр, нэг ч хүн. Машиныуд замын гарцаар нөгөө талд нь гарав. Энэ талд нь утасны шон алга.

Одоо хаашаа явдаг билээ? Грязное тосгон төмөр замаас тун холгүй, ердөө хоёрхон километрээс илүүгүй зайтай, гарц руу нуруугаараа зогсох юм бол баруун гар талд байх ёстойг Саша мэднэ. Гэхдээ эргэх газар хаахна байгааг шуургатай харанхуй шөнө яаж олох билээ?

– Эргэн тойронд хайцгаая, замын хаалтан дээр хэн нэгэн байх ёстой доо гэж Саша хэлэв.

Халшин нэг газар байшин руу тулж оччихоод, Сашаг дуудав. Цас хунгарлачихсан хэдий ч доошоо орох гишгүүр ил, бас яндан цухуйж байна. Нэг хоёр тогшлоо. Дахтай, эсгий гуталтай өндөр янхигар хүн гарч ирэв. Замчин юм байж. Арван нэгдүгээр сарын 24-нөөс хойш Михайлов, Павелец хоёрын алинаас нь ч галт тэрэг ирээгүй. Гэтэл эхнэр тэр хоёрт өртөөгөө орхиж явах эрх байхгүй. Алба.

– Германууд энд ирсэн үү?

– Үгүй, ирээгүй, тэднийхний онгоц бол нисч байгаа, тийм юм бол байна.

Савхин гуталтай хөл нь бээрэн, Саша дэмий л хөлөө сэлгэнэ, даавуу малгайг хичнээн даравч ямар нэмэр байх вэ, хоёр чих нь хөлдөх нь.

– Дайнаас өмнө энд зам засч байсан, далан дагтаршуулагч явсан байгаа, та мэдэх үү?

– Мэдэлгүй яахав. Та дээр нь зогсож байна шүү дээ.

Саша орчноо харав.

– Шуудуу ч байхгүй, элс хайрга ч байхгүй юмаа.

– Энд шуудуу ухаагүй, элс хайрга ч авчраагүй, дагтаршуулагч бол үүгээр явсан, тэр бол гарцаагүй.

– Замын шонгууд?

– Ойчсон ч байж магадгүй, ямар шуурга тавьж байгааг харж байгаа биз дээ. Яков Трофимович Блинов Грязное-д суудаг юм, замын хянагч, тэр л шонгуудыг харж хандаж байх ёстой.

– Грязное руу эргэх зам хаа байна?

– Хоёр километр хэртэй яваад баруун гар тийш эргэнэ.

– Пронск руу дагтаршуулсан далангаар явж байгаа юу?

– Үгүй, Грязное-гоос Пронск руу өөрийн замтай, чарганы зам. Далан чинь ил газраар явж байгаа, чарганы бол илүү эвтэйхэн, хүн амьтан яваад дасчихсаныг ч хэлэх үү, яасан болохоор...

– За, өвөө, толгойн машинд суугаад замаа зааж аль.

– Юуг нь заах вэ дээ, хоёр километр яваад баруун гар тийшээ эргэчих.

– Харин тэрийгээ л заагаад аль, суугаад яв, суу!

– Тэгвэл хүлээж бай, дахаа нүцгэн нөмөрчихсөн, холхиндог гуталтай байна, хувцаслая, эмгэндээ ч хэлье.

Замчин тонгосхийгээд нүхэн гэр рүүгээ орчихов.

Замын гарцан дээр гэрэл сүүмэгнэн Стрельцовын тавт ирлээ. Саша бүгдийг нь газарчинтай тосгон руу явуулаад, эргэх газар дараагийн тавтдаа зам заах нэг машин үлдээхийг тушаав. Проценкод байр олох үүрэг өгөөд, өөрөө Халшины машинтай дараагийн машинуудаа хүлээхээр үлдэв.

– За, Николай, тэсзэнэ, түрүүчийн машин ирэнгүүт чамайг тосгон руу явуулна, би өөр машинд шилжиж хүлээнэ.

Халшин чимээгүй сууж байв. Хариугүй осгох нь ээ царай нь... Саша ч байдгаа давхарлаж өмссөн хэдий ч бээрчихэж.

Тэгж тэгж Байков гурван машинтай ирэв, өөрийнх нь дөрөв дэх нь... Тав дахь нь хаачив?

– Чөтгөр л мэдэх байх. Журавлёв л хамгийн сүүлд явж байсан юм. Хоцорчихож л дээ янз нь, гүйцээд ирнэ биз.

Байков үстэй малгайтай, эсгий гуталтай байхыг бодвол гэрээсээ л авч яваа байх, юм нөөдөг хашир хүн.

– Чи чинь, араасаа хэдэн машин явж байгааг хардаггүй юм уу, хаашаа юм? гэж Саша хөмсөг зангидав.

– Сонин юм ярина шүү! Би яаж харах юм? Чи бол жолоочтой, би өөрөө жолоогоо мушгиж явна, би ямар ардаа нүдтэй биш. Журавлёв алга болчихгүй, ямар нялх хүүхэд биш!

– Чиний араас машиныг чинь түүж явах хүн байхгүй. Чи таван машинаа бүрэн хариуцах ёстой. Журавлёв замаа алдчихсан ч юм сан уу! Буцаж явж түүнийг олж ир.

– Би энэ шуурганаар явах юм гэнэ хэмээн Байков хямсалзав. – Хаанахын дарга гараад ирэх нь энэ вэ, их юм болж дээ.

– Зай гайгүй ээ, чи.

– Бага шиг сүрдүүл, чам шиг юмыг үзэхээрээ нэг боллоо!

Саша гар бууныхаа хуйнаас барьж авав.

– Явах уу, үгүй юү?

Байков гар бууг харснаа, Саша руу харчихаад машин руугаа очиж хөдөлсөн боловч эргэсэнгүй, харин урагшаа яваад өгөв. Ёстой муу шаар!

– Та тэр муу хорхойг буудчихгүй яасан юм гэж Халшин өгүүлэв.

– Тэгчихвэл машиныг нь хэн барих вэ? гэж Саша учирласан боловч өөрийнхөө хүчин мөхсийг аргагүй мэдрэв. тэрээр дарга биш, түүнд захирагдах алба байхгүй. За яахав, цуваагаа л яаж ийгээд Пронск хүргэчих юм сан.

Чураковыг тавттайгаа ирэхэд үүр хаяараад эхэллээ.

– Журавлёв чамтай тааралдсангүй юү? гэж Саша асуув.

– Зам дээр зогсож байна, асаагуур нь суучихаж, тэгсэн чинь Байков гэж нэг муу хуурс хаячихаад явчихаж! Би үзэж барилаа л даа, трамблерийг солихгүй бол болохгүй, засварын машин араас нь ирээд сольчихно. Журавлёваас болоод жаахан саатчихлаа, тэрний машиныг тойрч гарах гэж байгаад нэг машин замын хажуу руу орчихоод, арайхийж гаргалаа.

– Трамблер ямар хамаатай юм, Журавлёвыг Байковын тавтынх болохоор чи туслая гэсэнгүй, та хоёр хуцалцсан байна. Та хоёр хоёулаа баасны савнууд.

– Чи намайг элдвээр битгий хэлээд бай! гээд Чураков Саша руу давшлах юм болов.

– Хөөе, хөөе, аядаарай! гээд Халшин Сашаг халхалж, – Хэлхээтэй хэдэн ясыг чинь буцааж эмхлэхийн аргагүй болгоод өгнө шүү гэв.

– Чи тоол! гэж Чураков хийрхэн хашгачив. – Машинаа тоол! Тав байгаа биз дээ! Би эд нарын төлөө л хариуцлага хүлээж байгаа. Бусдын юмыг надад битгий тохоод бай.

– Явцгаа! гэж хэлэхээс өөр юм Сашад үлдсэнгүй.

Гурьянов, Мешков хоёрын машинууд, бас засварын машиныг Журавлёвтой ирэхэд үүр бүр цайчихлаа.

Саша Овсянниковын бие ямар байгааг Тонягоос асуув.

– Ашгүй унтаж байна, хүргэчих байх гэж бодож байна.

– Тосгонд очихоороо тэнд эмнэлэг байгаа эсэхийг мэдээрэй.

Саша Грязное тосгон руу хамгийн сүүлд орж ирэв. Проценко бүхээгт нь орж ирээд, хүмүүс

нь бүгдээрээ хооллож ундалсан, одоо амарч байгаа, том тосгон учраас машинууд нь гудамж хорооны үүгээр түүгээр тараад байрлачихсан, дээрээс тэр болгон харагдахгүй, нэмэрт нь цас пургэчихээд байна гэж илтгэв.

Проценко Сашаг байранд нь аваачив. Дулаахан сайхан модон байшин, хоёр хөгшин, бэр, хэдэн ач. Эелдэг зантай угтсан ч, нэг их нүүр өгч хөл алдсангүй. Саша бусад тосгонд сайхан найрсаг хүлээж авч байсан болохоор жаахан гайхсан аж.

Саша гутлаа тайлж, пийшингийн хавьд хөлөө жаахан ээгээд, оймсоо сольж, айлын байцааны халуун шөл идээд, замын хянагч Блинов руу явав. Нойр нь хүрч, толгой нь хар аяндаа гулзайгаад байсан боловч биеэ барив.

Блинов гэж баргар царайтай хүн: барилгын материалыг зөвхөн Дурное тосгон хүртэл зөөж авчирсан, замын хажуугаар хэвтэж байгаа, замын шонгууд ойчсон байж магадгүй, гурав хоног шуурч байна. Замыг хажуугийн ховил шуудуугаар баримжаалж болно, тэр хүртэл арваад километр гэжээ.

– Бидэнтэй явж, шуудуугаа зааж өгнө дөө гэж Саша хэлэв.

– Би явах хэрэг юу байна?

– Та чинь хянагч, замын дарга шүү дээ...

– Замын үйлчилгээнд ажиллаж байсан, тэр бол үнэхээр тийм, одоо бол миний алба хэнд хэрэгтэй юм? Ер нь ч би хаашаа ч явж чадахгүй, нуруу тэнийхгүй байна. Радикулит.

– Явах л болно доо, даханд ороогоод бүхээгт суулгачихна, тэгээд явна даа!

Блинов Саша руу муухай харав.

– Та нар хэзээ гарах санаатай байна?

– Орой тийшээгээ. Бүрий болохоор хөдөлнө.

– Хүлээх хэрэг юу байна?

– Манайхан хоёр шөнө унтаагүй, хөл дээрээ тогтохгүй байна...

– Шуудуу хүрэх замыг өдөр цэвэрлэх учиртай, шөнө бол талд төөрчихнө. Хамтралын дарга руу, Галина Ильинична дээр оч, хүртэй хүмүүс гаргаж өг гэж хэл, чадах чинээгээрээ цэвэрлэнэ биз, би заагаад өгнө.

Хамтралын дарга Галина Ильинична гэж ноосон цамцан дээрээ одон зүүсэн биерхүү авгай царай барайлган байж Сашаг сонсов.

– Манай тосгоныхон гэж хэн байна гээч? Өвгөд, авгайчуул, хүүхдүүд.

– Москвад хүүхнүүд танк эсэргүүцэх шуудуу ухаж байгаа, хаа сайгүй хүнд байна.

– Мэднэ ээ, сонссон, уншсан хэмээн дарга авгай мишилзэв. – Москвад чинь дайсныг явуулахгүй гэж шуудуу ухаж байгаа шүү дээ, гэтэл бид манийг хамгаалагч хөвүүд маань дайснаас аль болохоор хол зугтааг гэж зам цэвэрлэх хэрэг үү? Тийм юм биш үү?

– Үгүй шүү гэхээс өөр үг саяны учиртай үгэнд мэл гайхсан Сашад олдсонгүй.

– За чи, жишээ нь, нөгөө ялгах тэмдэг энэ тэр чинь хаа байна? Чамд дөрвөлжин, гурвалжин ямар тэмдэг байх ёстойг би мэдэхгүй. Өрсөж авч хаячихаад, олзонд очих гэж бэлтгэж байна уу?

– Би дарга биш, сумангийн дарга алагдсан, салаан дарга хүнд шархадсан, байлдагч би командлах ёстой болчихоод байна. Пронск руу, өөрийнхөө дивизид очихоор явж байна. маньд ингэж явахад амар байсан гэж битгий бодоорой.

– Наадахаас чинь юу ч өөрчлөгдөхгүй гэж авгай зөрөв. – Германууд Михайловт ирчихээд байна, энүүхэнд гар дор байна, өнөө маргаашгүй энд ирнэ, гэтэл та нар зайлж байна, тэгээд та нарт гөлчийсөн зам бэлтгэж өгч байх ёстой юм гэнэ. Та нар яагаад биднийг цуг авч явахгүй байгаа юм? Яагаад биднийг энд үлдээж байна?

– Явцгаая л даа! Бушуухан машинд сууцгаа, мэдээж, хүрзээ авна шүү дээ, зам гаргахад тусалцгаана. Алив, түргэн эмхэрцгээ!

Авгай санаа алдав:

– Одоохондоо эндээс явах, малаа туух тухай шийдвэр алга байна. Малаа хаячихаж болохгүй!

– Шийдвэр байхгүй... Гэтэл бид? Бид бол жирийн цэргүүд. Тийм л байна...

– Тийм байж ч магадгүй... Гэхдээ гомдмоор юм. Ингэж ч байлдах гэж. Рязанийн нутагт татараас хойш дайсан байгаагүй. Гэтэл одоо нөгөө ялагдашгүй, дийлдэшгүй арми маань... Арагшаа биш урагшаа явж баймаар юм даа, тэгэх юм бол бид замыг чинь туужуураар ч болохноо цэвэрлээд өгнө шүү дээ... Манай хүүхнүүд хэн нь сүүний тасаг дээр, хэн нь шувууны аж ахуй дээр гээд цөм дор бүрдээ ажилтай... За яахав, захиргаа руу машинаа хөөгөөд ир, боломжтой хүмүүсийг цуглуулъя. Блиновыг аваад ирээрэй.

– Тэр ч заавал. Ингэхэд, тэр чинь жаахан ууртай хүн юмаа даа.

– Юундаа баясах билээ? Хоёр хүү нь алуулчихсан, дөнгөж таван сар байлдаж байдаг, гэтэл

хүүгүй болчихсон.

Хоёр машинаар гарлаа. Саша хажуудаа Блиновыг суулгаад эхнийхийг нь өөрөө, хоёр дахийг нь Халшин бариад замд гарцгаалаа. Саша түүнд,

– Николай, явцгаая, чи л тусал! гэжээ.

Яг зам эргэх газраас эхлэн цэвэрлэж эхлэв. Блинов гагцхүү өөрөөс нь өөр хэн ч мэдэхээргүй тэмдгээр зүгээ тодорхойлон урагшлана. Авгай хүүхнүүд түүний араас арайхийн амжиж байв. Саша, Николай хоёр бас цэвэрлэлцэн, буцаж ирж машинаа нэгэнт цэвэрлэсэн зам дээгүүр дүнгэнүүлж ирээд дахин хүрздэнэ.

Залуу хүүхнүүд өөр хоорондоо ганц нэг үг солилцон, баргар царайлан ажиллацгаана. Саша, Николай хоёрыг харж байгаа ч юм алга. Харин үстэй дээлнийхээ дээгүүр алчуураа зөрүүлэн зангидсан нэг арай ахимаг авгай,

– Танайхны жолооч нар гэж гарз ноход шиг юмнууд байж өөрсдөө замаа цэвэрлэж чаддаггүй юм уу? гэж үглэв.

– Тэд нар чинь хоёр шөнө нойргүй яваа улс, өнөө шөнө дахиад замд гарна. Жолооч жолооныхоо ард унтчих юм бол өөрийгөө ч, машинаа ч бодийг нь хөтлөнө.

– Хүүхэнтэй бол өөрөө ч шөнөжин унтдаггүй, хүнийг ч унтуулдаггүй байлгүй, тэгсэн чинь жолооны ард бол унтчихдаг байх нь, яасан энхрий амьтад вэ!

Николай хэдэрлэх гэсэндээ биш,

– Ямар хүүхэн гэдгээс л болох юм чинь... Салахын аргагүй нэг байхад, шууд буруу харж хэвгээд өглөө болтол хурхирахаас өөр яалт ч үгүй хүүхэн ч бий шүү дээ. Ялангуяа дэндүү олон үгтэйгээс бол гэж цаашлуулав.

Сашатай зэрэгцэн ажиллаж байгаа тэр авгай түүний яаж малгайгаа доош нь дарж, яаж гар хуруугаа үлээж байгаа энэ тэрийг хараад, өрөвдөх, зүхэхийн хооронд,

– Машиндаа л сууж байхгүй, ийм гуталтай салхи авчихна даа гэв.

Саша өөдөөс нь инээмсэглэн,

– Шуудуу хүртэл цэвэрлэчихээд тосгонд буцаж очно гэв.

– Би чамд үстэй малгай, бээлий, эсгий гутал авчирч өгнө өө, тэгэхгүй бол чи балрах хар толгойт байна.

– Тэгвэл баярлана шүү.

Сар мандаж, Блинов ч малтахаа болиод,

– За нөгөө шуудуу чинь энэ байна! гэв.

Хэдийгээр цас хунгарласан ч замын хоёр талын шуудуу зарим газраа тод, зарим газраа мэдэгдэх төдий харагдаж байна.

– Цасанд дарагдсаныг нь хүрдээд мэдчихэж болно. Эндээс арваад километр явахад замын хажууд баахан юм овоолоотой байгаа, жаахан цаашлаад замаас зайдуухан тосгон байгаа, тэр бол Дурное.

Цэвэрлэсэн замаараа Грязное-д буцаж ирцгээв. Саша Блиновтой салах ёс хийв.

– Яков Трофимович танд их баярлалаа.

– Өө, тэр яахав... Дурное-гоос Пронск хүртэл арван таван километр гэж үздэг юм. Замын уулзвар дээр МТС-ийн салбар бий, хэдэн модон байшин байгаа...

– Би тэр хавийг мэднэ...

Саша айлдаа ирээд шинель, гутлаа тайлж, хөлийнхөө чилээг гаргах гэтэл толгой нь өвдөж, нуруугаар нь янгинаж байгааг мэдрэв. Байранд сайхан дулаахан атал бие нь жихүүцээд ирлээ. Арай л салхинд цохиулчихаагүй байгаа даа, тэр л дутаж гэнэ дээ! Хоол идэх дур алга, тэглээ ч халуун шөл хэд халбагадаж, агшаасан будаа идээд, пийшингийн дэргэдэх вандан дээр элдвийг умартан зүүрмэглэв.

Саша Проценког жолоон дээр суулгаад, өөрөө бүхээгний мухар руу шигдэн жаахан дугхийв. Бусад нь өдөр нойроо авчихсан, мань хүн цурам хийж амжаагүй яваа билээ. Нөгөө авгай үнэнхээсээ малгай, бээлий, гутал авчирч өгсөн, дулаахан хувцастай гэмээр атал, хамаг бие нь жихүүцэн, толгой нь даагдахгүй, нэг л бүлээцэж өгөхгүй байв.

Жолооч нар үстэй малгайтай, зарим нь эсгий гуталтай болчихож, тосгоныхон өрөвдсөн байх нь. Германы олз болгож байснаас өөрснийхөндөө өгсөн нь дээр гэж бодсон ч байж магадгүй.

Машин зогслоо.

– Цаашаа зам алга гэж Проценко хэлэв.

Саша бүхээгнээсээ гарав. Тэд нар энэ хүртэл цэвэрлэсэн, эндээс л буцацгаасан.

Тэргэл сар цаст хөндийг гийгүүлжээ. Ар тал руу олон машины гэрэл харанхуйд уртаас урт зурайж байна. Саша Проценког цуваа руу явуулж, бүгдийг нь гэрлээ унтраагаад, хүрэээ бариад ир гэж хэлүүлэв.

Саша Шемякин, Сидоров гэдэг хоёр слесарьт замын ирмэгээр явж, шуудууг хүрзээрээ тоншилж явахыг үүрэгдээд, өөрөө замын голоор дэвслэн зүг гаргаж, араас нь Николай Халшин, түүний хойноос суман тэр чигээрээ цуварлаа. Эцэст нь зогсоцгоож, цасаа ухаж эхлэв.

– Энэ хэсгийг дуусангуут машинаа нааш нь хөөж авчраад, тэгээд дахиад миний араас явна шүү гэж Халшинд хэлэв.

Саша явах биш, сажлах төдий салгалж, хоёр слесарийн барааг харж, тэдний хооронд явж байх ёстойгоо л мэдэж байв... Тэгсэн чинь нөгөөдүүл нь гэнэт алга болчихов... Нүдээ нээтэл слесарь Шемякин мөрнөөс нь сэгсчиж байж.

– Панкратов, чи чинь дороо дэвслээд яаж байна. Зүүрмэглэчихсэн юм уу, хаашаа юм?

– Бүү мэд гээд Саша инээх гэсэн боловч уруул нь эвлэсэнгүй. – Шемякин, яв, би гүйцээд очно.

Машиныуд нь дөхөж ирж, гэрлээ унтраагаад, жолооч нар Сашагийн араас дахиад хүрзээ барин цувцгаав.

Тийнхүү километр километрээр ахилаа. Саша хичнээн хугацаа өнгөрснийг эс мэднэ, цагаа харах гэж бээлийгээ тайлахыг хүссэнгүй, эргэн тойронд гагцхүү сарны гэрэл туссан хөндий, баруун, зүүн талд хоёр слесарь явааг л харж байв. Тэгтэл замын хажууд нэг овоо харагдав.

– Наадахынхаа цасыг малтаатах гэж Саша слесарьт хашгарав.

– Тэгж таарна аа, бөөн элс байна, нөгөө талд нь баахан хайрга байна.

Одоо баримжаалах юмтай боллоо, зам хайх хэрэггүй боллоо. Жолооч нар машинаа хөөгөөд ирлээ. Тэнгэр хаяарах шинжтэй.

Жолооч нар машинаасаа гарч Сашаг тойрон цуглацгаав.

– Овсянников яаж байна гэж Саша Василий Акимовичоос асуув.

– Одоохондоо амьд шуу байна. Ухаан нь орж гараад л. Тоня үхжил үүсэх вий гэж айгаад байгаа.

– За нэг юм шийдэцгээе. Дурное тосгон замаас зайдуу байгаа, дахиад гурван километр цас ухах хэрэг болно, цаг алдана. Сүүлчийн дайралт хийгээд Пронск хүрчихье. Шуурга тавьж байгаа юм чинь германууд нисэхгүй байгаа гэсэн үг. Хэдэн цаг яваад хүрчихнэ, тэгээд дулаацацгаана.

– Хүмүүс эцэж цуцаж гүйцлээ, осгосон хүн ч байна, Тонягийн тос ямар ч нэмэр болсонгүй, тосгон руу очих хэрэгтэй гэж Байков Сашагаас зөрүү харж хэлэв.

– Осгосон хүмүүст тосгоныхон юугаар ч тус болохгүй, харин Пронскт бол эмнэлэг байгаа, Овсянниковыг тийш нь аваачих хэрэгтэй, мань хүн хариугүй байна.

– Пронск явах хэрэгтэй гэж Чураков Сашаг дэмжив. Байковтой л зөрж байвал болдог хүн.

– За шийдлээ. Машинаа дүүртэл дүүртэл цэнэглэцгээ, тэгээд явцгаая.

Бүгдээрээ хувин авахаар явцгаахад Чураков түр саатан,

– Чи тэр нэг армяны төлөө үхэх юун дуртай юм? гэж доогтой асуув.

– Юун армян? хэмээн Саша гайхав.

– Яагаав, нөгөө гээд Чураков дээш харав.

– Тэр чинь армян биш гүрж. Бид чинь түүний ч төлөө байлдаж байгаа юм биш. Эх орноо хамгаалж байна.

– Ямар ухамсартай эд вэ! Эх орноо хамгаалж байна гэнэ. Чи өөрийгөө хараач, хөл дээрээ тогтохгүй байж. Юуны төлөө зүтгэж, юу гэж эвэрт олиулчих гээд байгааг чинь ойлгохгүй юм.

– Чураков, чи шоронгоос гарсан юм уу? Тэдний хэлээр яриад эхлэх чинь!

– Шоронгоос! Эвдэн сүйтгэсэн улс төрийнх. Тийм зүйл ангийг мэдэх үү?

– За тэр яахав, явж бензинээ ав, аягүй бол хоосон хоцроно шүү.

– Би хоосон хоцрохгүй. Харин чи цасан дээр погдойгоогүй дээрээ бүхээгт сууж яв. Чамтай чамгүй бид замаа олно.

Замын сүүлийн хэсэг маш бэрх болж таарав. Ялангуяа нам газраа. Хунгар малтана, машинаа түлхэнэ, осгосон, салхи авсан хэн хүнгүй ажиллаж байгаа болохоор Саша ч бас бууж хүрздэнэ. Тоня ердөө йод, самбай хоёртой, фронт дээр юуных нь салхинд цохиулах байх вэ дээ! Ямар ч эм байхгүй.

Зогсоо чөлөөгүй шуурч, явган шуурга хацар нүүр хайрна. Үдийн алдад хамгийн хэцүү газар хүрч ирэв. Эгц эрэгтэй гүнзгий жалга, ёроолд нь нэг горхи хөлдчихсөн байж таарна, дайнаас өмнө гүүр барьж амжаагүй, тэр ч бүү хэл, гууны хажууг тэгшилж гүйцээгүй, Саша энэ жалгыг мэднэ.

Түүгээр зам гаргах гэж их удлаа. Жалгын цаад ирмэгээс авахуулаад нэлээн хол цасыг нь цэвэрлэв. Дов сондуул, энхэл донхол ихтэй жалганаас олигтойхон хүчээ аваад гарчих нь гэж байхгүй, олон машин баахан уугчиж дүнгэнэлдэнэ. Заримыг нь түлхэнэ, заримыг нь чирнэ, зарим нь унтарчихна. Митька Кузины мотор унтарчихаад, мань хүн тамираа тасартал маниулаа эргүүлсний эцэст радиатортоо толгойгоо наагаад уйлчихав.

– Ээ зайлуул, нялх ч амьтан бол доо гэж Саша өгүүлэв.

түүний машиныг олуулаа элбэн түлхэж гаргаад, өөр машины аккумулятороос цэнэг өгч асаав.

Саша түрүүчийн машинуудаа Пронскийн хаяа гацаанд очиж, тэнд байр олж байрлахыг тушаагаад, өөрөө засварын машинаа гартал жалганд үлдээд, тэр машинаараа бүрий болж байхад гацаа руу ирэв. Шинелиэр хучсан Овсянников тэр машинд дэмийрэн тийчилж байгаа. түүнийг Пронск руу аваачиж, цэргийн эмнэлэгт, цэргийн эмнэлэг байхгүй бол дүүргийн эмнэлэгт хэвгүүлэх хэрэгтэй.

– Василий Акимович, та Тонятой яваад, осгосон хүмүүсийг яахыг мэдээд ир, маргааш өглөө хүргэж өгье гэж Саша Синельщикоивоос гуйв.

– Та өөрөө эмнэлэгт очих хэрэгтэй, халуураад байгаа чинь нүдээр чинь илт байна, бас наад уруулаа хар, хоолой чинь паржигнаж сөөнгөтөөд байна гэж Тоня өгүүлэв.

– Тэгвэл халуун дардаг нэг юм л олоод ир л дээ.

Николай, Проценко хоёр Сашаг нэг модон байшинд дагуулж оров. Тэнд нь Чураков, Стрельцов хоёр орчихсон байж. Энэ гацаа дөнгөж аравхан байшинтай, байшин болгонд тав таван хүн оруулсан аж.

Саша галласан дулаан байшинд орж, шинель, гутлаа тайлтал хамаг бие нь дахин зарайгаад, бүр шүд ам нь дагжаад, амьсгал нь давхцан, толгой нь янгинаад, нүд нь бүрэлзээд ирэв. Байшинд халуун, бүгчим аж. Олон хүн, охид бүсгүйчүүл хүртэл байгаа бололтой, сүрхий шуугилдаж байна. Ширээн дээр шилэн аяга, идэх юмтай тавагнууд байна. Стрельцов баяныхаа товчийг шажигнуулан нэг ая дарж байна, Сашагийн чих шууугиад, аяны учрыг ялгах юм алга. Вандан сандал дээр нүдээ анин суулаа. Гэхдээ нэг хүн бараг чихэнд нь,

– Одоо энүүнийг зад эмчлээд өгнө өө гэж хашгарахад Чураковын дуу гэж танив.

Саша нүдээ нээвэл, Чураков түүн рүү шилэн аяга сарвайж байв.

– Цэвэр спирт, нэг татчих!

– Усаар найруул гэж Николай хэлэв.

– Олигтой үйлчлэхгүй... Усаар даруулна биз... Алив, Панкратов, нэг балгачих!

Саша дахиад тонгойв.

– Алив, залуус аа, дэмнээрэй! гэж Чураков дуудав.

Николай Сашагийн толгойг өргөж, Чураков аягатайгаа ам руу нь хүргэв.

– Байз, би өөрөө яая...

Саша салгалсан гараараа аягатайг авч, ганцхан хөнтрөв. Хамаг хоолой, гэдэс дотор нь шатчих шиг болох нь тэр. Николай ус бэлэн бариад зогсож байв.

– Бушуухан ус уучих!

Түлчих гээд байсан нь дорхноо больж хөнгөрсөн боловч толгой нь эргээд, санаа бодол нь уймарч байна. Юун найр вэ? Спирт, идэх юм...

Николай түүнд хэрцсэн гахайн өөх, талх, давс, нэг сонгино энэ тэр тавганд хийж дөхүүлэв. Хаанаас ийм юм гардаг байна, юун тосгон билээ? Өө тийм, МТС, шинэ гацаа... Нөгөө Овсянников яагаа бол? Цэргийн эмнэлэгт амьд хүргэж чадаа болов уу? Буцаагаад аваад ирсэн бол яадаг хэрэг билээ?

Саша хүчлэн байж юухан амхрав.

– Бүлээцэв үү? гэж Чураков асуув.

Саша хариуд нь толгой дохив.

– Одоо бид чамайг жинхэнэ номоор нь дулаацуулна. Жорлонд ормоор байна уу?

Саша толгой сэгсрэв.

– Сайн бод, шөнө гаргахгүй шүү.

Саша дахиад толгой сэгсрэв.

– Проценко, энүүний үүргэвч хаана байна? Дотуур өмд цамц гаргаад ир, алив, залуус аа, энүүнийг тайчъя.

– Би өөрөө...

Гэвч Николай, Проценко хоёр түүнийг аль хэдийнэ тайчаад эхэлчихэж.

– Усан хулгана болчихож! Бүсгүйчүүд ээ, том алчуур өгөөтөх! Сайн арчина шүү, энүүнийг хэмээн Чураков халамцуу хүний ёсоор шуурхайлан, – Алив, Панкратов, бос, алив, залуус аа, пийшин дээр гаргая!

Пийшин улайстал халжээ. Саша ухартусан зулрав.

– Барьж бай наадахаа, битгий тавиарай! Панкратов, тэсээнэ, чи бишгүй командлалаа, одоо бидний командыг сонс!

Бүрмөсөн сунчин тасарсан Саша пийшин дээр дээшээ хараад унаад өгөв. Тааз нь яг дээрээс нөмрөх мэт намхан, толгой ч өндийх аргагүй, Саша дэмий л хөлөө жийн биеэ хөвчлөхөд жаахан гайгүй болж байгаа ч юм шиг. Пийшин дээр хатааж байгаа буудай юм уу, хөх тариа яггүй халуун хэрнээ нэг их түлчих гээд байх нь гайгүй аж. Николай Сашаг дэмнэсхийн барьж, Проценко алчуураар зүлгэв. Тэгсхийгээ Саша чимээгүй болж, муужирсан мэт хэвтэнэ. Николай түүнийг дахаар хучив.

Дор буй Чураков,

– Амьсгаатай байна уу? гэж асуув.

– Амьсгалж байна.

– Гайгүй болно, байн байн сайн арчаад бай, шалдан хэвтэж байг. Бүсгүйчүүл бүү ойртуул, гэхдээ мань хүн юун бүсгүйтэй мантай байгаа, тийм биз дээ, Панкратов?!

Саша Чураковын хэлж байгааг ялгаж сонссонгүй, чих нь шуугисан хэвээр, манан будан дотор байгаа мэт харанхуйлан, халуун пийшингийн хайралтыг багасгах гэж доогуураа дахны захыг хөлөөрөө тумлайдаж хийх санаатай оролдож байгаад дахин нойронд автав.

Саша спирт уучихаад, улайсмал пийшин дээр бүтэн шөнө тэсэхийг бодоход лут бөх хүн бололтой... Өглөө сэрэхэд бие нь овоо хөнгөрсөн, зөвхөн цээжээр жаахан хатгаж, далных нь доогуур янзгүйрхэх маягтай байв.

– Гадаа салхинд битгий гараарай, хөлийн өрөөнд хувин байгаа, угаагуур гал тогоонд байгаа гэж Николай анхааруулав.

Саша хөлийн өрөө рүү орж, гар нүүрээ угаагаад, хувцас хунараа өмсөв. Савхин гутлаа өмсөхийг нь хараад Николай,

– Эсгий гутал өмс гэж хэлэв.

– Цэргийн хэлтэс рүү очно, номоороо байлгүй болохгүй. Василий Акимович эргэж ирсэн үү?

– Ирсэн. Овсянниковыг эмнэлэгт орхисон. Осгосон хүмүүсийг байр байхгүй гээд авахгүй байна. Тоня эм авчирсан.

Саша вандан дээр суув. Дахиад толгой нь эргэсэн боловч бие нь тавирсан болохоор сульдаа нь аятайхан ч юм шиг.

Проценко, Чураков хоёр босч нүүр гараа угаацгаав.

– Стрельцов хаана байна? гэж Саша асуув.

– Мэдээж шүү дээ, сүйт бүсгүй дээрээ л байгаа.

– Тэр чинь тосгон болгонд сүйт бүсгүйтэй.

Проценко, Чураков хоёр ч ширээ рүү суулаа.

– Жаахан хөнгөрөв үү? гэж Чураков асуув.

– Хөнгөрсөн юм шиг байна.

– Халуун усныхаа газрыг даанч галлаагүй гэнэ, түүнээс биш уураар угаад, навчин шүүрээр балбачихгүй юү, гэхдээ өөр аргаар чамайг бүлээцүүллээ. “Ардын эмнэлэг” гэдэг юм. Юм идэх үү?

– Иднэ ээ.

– Тэгвэл эрүүл гэсэн үг. Чи ханиаж, цээж чинь хэржигнэж байна ингээд зүгээр болно. Хэдэн дусал хүртчих, бүрмөсөн тэнхрэнэ гээд Чураков лонх руу дохив.

– Болохгүй. Хот руу, цэргийн хэлтэс рүү явна.

– Нусаа гоожуулаад чи хаашаа очих нь вэ? Ганц өдөр хэвтчих. Хот руу Гурьянов, Синельщиков хоёрыг явуулчих, намын гишүүд юм чинь ёсоор нь илтгэчихнэ. Чи бол юм балгасан чинь дээр гэж Чураков өгүүлэв.

– Би уухгүй, та нарыг ч битгий уу гэж зөвлөө.

– Уучлаарай, жанжны зуун грамм хууль ёсных.

Гэрийн эзэгтэй гахайн өөхөөр хайрсан өндөгтэй том хайруулын таваг ширээн дээр тавив.

– Амьдрахыг үзүүлж байна шүү, гахайн өөх, архи... Хаанаас ийм юм олдог байна?

Чураков Проценког толгой дохин заав.

– Хангамжийн дарга бидэнтэй хамт яваа шүү дээ.

– Энэнийг чинь ийм баян гэж мэдсэнгүй л дээ.

– Панкратов, чи бол дүйрэн. Тийм болохоор чинь л чиний үгэнд орж байгаа юм. Орос хүн өөрөө тэнэг учраас аливаа дүйрэнг хүндэлдэг юм, яагаад гэвэл дүйрэнгүүд чинь илүү тэнэг. Тэгээд л өөрөөс нь тэнэг хүн байгаа гэж бодохоор Тэнэг-Иванд таатай байгаа юм шүү дээ.

– Би юугаараа тэгтлээ тэнэг байна?

– Чи чинь жолооч шүү дээ. Машиндаа ганц шил архигүй, хэрчим гахайн өөхгүй жолооч яаж явах болж байна? А-аан?! Өөрөө бодоод үз...

Байшингийн гадаа моторын дуу гарч, чанга чанга ярих сонсдов...

Николай малгайгаа духсан болж, шинелиэ хэдрээд харахаар гарснаа эргэж орж ирэв... Араас нь Байков, дөрвөн танихгүй цэргийн хүнтэй орж ирсний хоёр нь бүсэндээ гар буутай, тэгэхээр дарга нар, хоёр нь автомат буутай, тэгэхээр байлдагч нар байх нь. Нүдний шилтэй, намхан бүдүүн хошууч ширээний ард суугсад руу нүдээ бүлтийлгэн харав.

Байков Саша руу зааж,

– Манай командлал энэ байна гэв.

– Та сумангийн дарга уу? гэж хошууч ширүүн асуув.

– Сумангийн дарга алагдсан.

– Удирдах бүрэлдэхүүнээс хэн байна?

– Энд хэн ч байхгүй. Салааны дарга, цэргийн техникч Овсянников Пронскт, эмнэлэгт байгаа, шархадсан.

Хошууч вандан дээр сууж, малгайгаа хажуудаа тавиад, оготор дээлийнхээ энгэрийг ярав.

– Дарга нар нь алагдсан, байлдагчид нь бүрэн бүтэн байгаа байж.

– Тийм дээрээ л тулаад байна.

– Тэгвэл та хэн болж байна?

– Жолооч, байлдагч.

Хошууч Байков руу харав.

– Суманг хэн командалж байсан юм бэ?

Байков дахиад Сашаг заав.

– Энэ л командалж явсан юм.

– Би командлаагүй, зам мэддэгийн хувьд суманг нааш нь дагуулж ирлээ.

– Энэ чинь техникийн туслах гэж Николай хөндлөнгөөс оролцов.

– Таныг техникийн туслахаар хэн томилсон юм?

– Техникийн туслах Брянскийн хавьд алагдсан. Орны хүнийг иртэл намайг үүргийг нь гүйцэтгэж бай гэж сумангийн дарга даалгасан юм.

– Тушаал хаа байна?

– Амаар тушаасан.

– Та чинь яасан сонин үлгэр надад яриад байна аа!

– Нөхөр хошууч, манайд чинь гартаа ташуур авсан нь л дарга болдог журамтай гэж Байков бүдүүн дуугаар хүнгэнүүлэв.

– Чи муу баастай нударган дуугаа тат! гэж Чураков зандрав.

Хошууч ширээ шаав.

– Ямар хэл яриа вэ! Яагаад хөндлөнгөөс дайраад байна? Танаас хэн асуугаав?

– Тэгвэл та юу гэж над руу нудрага зангидаад байна? Тэгдэг нь та юм уу? гэж Чураков сөрвөлзөв.

– Би юуг тэгдэг, юуг тэгдэггүйгээ чамд үзүүлээд өгнө шүү! Би бол...

– Үгүй шүү! Та нудрага зангидах эрх байхгүй! Ер нь та хаанахын, хэн юм бэ?! гэж Саша тэдний яриаг тасдав.

– Би армийн тусгай хэлтсийн дарга.

Саша тэднийг ойрд хараагүй, тэд нар фронт дээр тааралдаагүй, одоо хэр нэгтэй нь ч учраагүй явна! Энэ хошууч Уфад Глебийг баривчилдагтай ямар адилхан юм бэ, муусайн новшнууд, нүүр царай нь хүртэл яг даа!

– Ойлгов уу, миний хэн гэдгийг? Харин та нар юун улс болохыг бид учрыг олно.

– Юуных нь учрыг олох юм?! Бид Улаан Армийн дайчид байна гэж Николай хэлэв.

– Улаан Армийн дайчид фронт дээр байлдаж байгаа гэж хошууч сургамжлан хэлээд, Сашагаас, – Та энд удаж байна уу? гэж яаравчлан асуув.

– Энэ сууринд урьд шөнө ирсэн.

– Хоёр хоног нүд аниагүй гэж Николай нэмж өгүүлэв.

– Яагаад дүрэмт хувцасгүй байна? Яагаад энгийн малгайтай байна? Хаанаас авсан юм? гэж хошууч түүн рүү дайрав.

– Хүмүүс өгсөн юм.

– “Хүмүүс”! Нэмэрт нь бас тонуулчид байх нь! гэснээ хошууч дахиад Сашад хандан, – За урьд шөнө ирсэн байж, одоо хаачих гэж байна? гэв.

– Пронск руу, цэргийн хэлтэст очно.

– Та нарын цэргийн хэлтэст яаж очих гэж байгааг харж байна. Өглөөнөөс архи гудраад, муусайн тонуулчин архичид! гээд дэслэгч рүү дохиход цаадах нь ширээ рүү сууж, аяга тавгийг түлхэн зайчлаад, цүнхнээсээ цаас, бэх, үзэг гаргаж бичихээр зэхэв.

Овог нэр, төрсөн газар, он гэхчилэнгийн танил асууултууд. Ял заагдаж байсан эсэх...

– Байгаагүй гэж Саша хариулав.

– “Өөрийнх нь амаар бол заагдаж байгаагүй” гэж бич гэж хошууч тушаав.

Гадаа дахиад моторын дуу гарснаа чимээгүй болов. Үүд нээгдэн хурандаа орж ирэв.

– Нөхөр хошууч, авто сумангийн даргыг нэн даруй өөр дээрээ авчир гэж командлагч тушаалаа.

– Байцаалт явуулж байна, харж байгаа биз дээ.

– Нэн даруй авчир гэж тушаасан! Хошууч аа, цаг битгий алд! Авто сумангийн дарга хаана байна? гэж хурандаа бачимдан шаардав.

Хошууч Сашаг заав.

– Энэ байлдагчийг эд нар дарга гэж байгаа юм.

– Түргэн хувцасла! гэж хурандаа тушаав.

Саша мөрөвчөө углахад түүнээс нь Березовскийн гар буу зүүлттэй байв.

– Хэний хувийн зэвсэг вэ? хэмээн хошууч сэрдхийв.

– Сумангийн даргынх.

– Хураалга!

Саша мөрөвчнөөсөө хуйтай гар бууг мулталж ширээн дээр тавив.

– Өөрөө эрхгүй мөртлөө хувийн зэвсэгтэй байсныг тэмдэглэ гэж хошууч дэслэгчид тушаав.

– Явцгаая, явцгаая! гэж хурандаа яаруулав.

Саша шинелиэ өмсөв.

– Та нар чинь яагаад ганц энийг авч явж байна, бүгдийг маань аваач дээ гэж Николай хэлэв.

– Хэрэгтэй үед нь авах болно гэж хошууч хариулаад, хурандаа, Саша хоёрын араас гарав.

Германууд хоёр долоо хоног амсхийгээд, арван нэгдүгээр сарын дундуур довтолгооноо дахин эхлэв. Хэдийгээр Москвагаас хорин долоон километр байгаа Красная Поляна сууринг хүрсэн боловч энэ довтолгоо мухардана гэдгийг Жуков ойлгож байв. Германууд Улаан Армийн хариу довтолгоог нэгэнт даахаа больжээ. Өргөн далайцтай хүчирхэг цохилтыг бол бүр тогтоож чадахгүй. Жуков арван нэгдүгээр сарын 29-нд Сталинд утасдаж, сөрөг довтолгоон хийх тухай тушаал буулгахыг хүсэв.

Сталин чимээгүй болзнов. Энэ бол эргэлзэж байгаагийн шинж гэдгийг Жуков мэднэ.

– Дайсанд томоохон нөөц бүлэглэлүүд байхгүй гэж итгэлтэй байна уу?

– Мэдэхгүй. Гэхдээ дайсны хошуурсан довтолгоо аюултай болж байна, үүнийг заавал устгах хэрэгтэй.

Орой нь Бүх цэргийн жанжны газраас сөрөг довтолгоон хийхийг зөвшөөрөв. Баруун фронтын штаб тэр довтолгооныг арван хоёрдугаар сарын 3-нд хийхээр товлон. Бэлэн байгаагаа Аравдугаар армийнхаас бусад бүх командлагчид нотлов.

Сталин бүр аравдугаар сард Жуковоос,

– Коммунист хүн шиг яг үнэнийг хэлээрэй! Бид Москваг алдахгүй байж чадах уу? гэж асуужээ.

– Гарцаагүй чадна. Гэхдээ хоёр арми, хоёр зуун танк хэрэгтэй.

Танк өгөөгүй, гэхдээ Жуковт хоёр арми өгсөн нь: Нэгдүгээр гавшгай арми, Аравдугаар арми. Нэгдүгээр гавшгай армийг туршлагатай генерал Василий Иванович Кузнецов командлах болсон. Харин Аравдугаар армийн коамндлагчаар Сталин Голиковыг томилжээ.

Голиков дайны өмнө Тагнуулын ерөнхий газрын дарга байсан, байлдааны туршлага байхгүй, ухаантай, зальтай, Сталинд тал засагч. Тэр арми Волга орчмын нутагт бүрэлдсэн, тэгээд өөрийн мэдэлд ирэхэд нь Жуков түүнийг нөөцлөн, Рязаниас өмнөхөн байрлахыг тушаажээ. Одоо энэ нөөцийг ажилд оруулах болж байгаа юм. Гудерианы танк Москваг бүсэлж гүйцэхийн тулд өмнөөс хойш урагшилж яваа. Гудерианы арми сүрхий сунасан, баруун жигүүр нь хамгаалалтгүй байгаа учраас тэр талаас нь хүчтэй цохилт өгөх хэрэгтэй. Голиков энэ ажлыг хийх ёстой юм. Тэгсэн чинь яаж байна гээч... Голиков, арван хоёрдугаар сарын 5-наас нааш армия төвлөрүүлж чадахгүй гэж Сталинд илтгэжээ. Тагнуулын ерөнхий газрын дарга байхын өөрийн шууд дарга Жуковыг алгасан Сталинд илтгэдэг зуршилтай болсон хүн. Довтлох хугацааг тасалдуулж байгаа хэрнээ энэ тухайд ч гэсэн онцгой байдалд байх юм шиг гэж бодож байна. Тэр бүтэхгүй! Энэ бол Кремлийн албан тасалгаа биш!

Жуков Голиковыг фронтын штабт дуудан ирүүлэхийг тушаажээ.

Голиков Перхушковод арван хоёрдугаар сарын хоёронд ирэв. Бахим биетэй, халзан толгойтой,

залуурхуу махлаг царайтай тэрээр хуучин зангаараа инээмсэглэсээр орж ирлээ. Тэр голдуу Сталин дээр очоод ирэхдээ тэгж инээмсэглэдэг, Жуков Жанжин штабт байхын тэр инээмсэглэлд дургүй. Голиков Сталинд хоёр хавгастай очиж илтгэжээ. Сталиныг муухай зантай байвал тайвшруулах мэдээ өгнө, сайхан зантай байвал үнэнийг ярина. Гэхдээ Сталин ямар нэг юмыг үнэмшихгүй бол тэр дороо санал нийлж, нөхөр Сталин таны зөв гэнэ, энэ бол нөгөө төөрөгдүүлэх мэдээ гээч нь билээ...

Сталинаас айхгүй хүн байхгүй, Жуков ч айна, түүний ихэнхдээ утгагүй, хор хөнөөлтэй шийдвэрт захирагдана. Гэхдээ өөрийнхөө байр суурийг заавал илтгэнэ. Нэг ч удаа Сталинд тал засч худлаа ярьж байгаагүй. Ингэсэн хүн тэр болгон зүгээр өнгөрөхгүй. Голиковоос өмнө цэргийн тагнуулын газрын гурван даргыг буудан алсан, Берзин, Урицкий, Проскурин гурвыг. Тэдний үнэн мэдээлэл Сталины сэтгэлд нийцэхгүй байж. Гэхдээ тэд шудрага коммунист чигээрээ үхэцгээсэн. Тэгвэл Голиков бол худал мэдээлэгч! Герман зургадугаар сарын хоёрдугаар хагаст Зөвлөлт Холбоот Улс руу довтолоно гэсэн Зорегийн цахилгаан дээр Голиков “Эргэлзээтэй, төөрөгдүүлэх мэдээллийн жагсаалтад ав” гэж цохсон байсныг Жуков өөрийнхөө нүдээр харсан. Тийм мэдээллийг дайн эхлэхээс гурван сарын өмнө хөсөр хаяж байгаа юм! Тагнуулын ажлын талаар ямар ч мэдлэггүй Голиков яаж тэр байгууллагыг тэргүүлж зүрхэлж байв аа? “Барбаросс”-ын төлөвлөгөөн дээр энэ бол англичуудыг мэхлэх зорилготой, төөрөгдүүлэх мэдээ гэж бичсэн гэж байгаа. Хулчгараасаа болж тэр!

Сталин одоо түүнд арми өгчихлөө. Голиков энд хүртэл шууд даргыгаа үл тоомсорлон, Сталинд шууд хандаж байгаа. Гэхдээ Сталин бол түүнийг шал тоохгүй! Фронт командлагчид түүнээс танкийн салаа болгоноо, батарея болгоноо гуйж царайчилж байж авч байгаа. Хамаг юмыг өөрийнхөө гарт авчихсан, бүгдийг өөрөөс нь, гагцхүү өөрөөс нь хамааралтай байлгах гэж тэр.

“Хэрэв зах дээр дивиз зардаг байсан бол би танд тав-зургаан дивиз аваад өгмөөр байна, даанч зах дээр зарахгүй юм даа”. Сталин Тимошенког ганц дивиз өгөөч гэхэд нь тэгж хариулсан ажээ. Тимошенкод тэр шүү дээ! Тэгэхэд энэ муу Голиков юу юм бэ!

– Би таны илтгэлийг авсан. Яагаад довтолж чадахгүй гээд байна? гэж Жуков царай өгөлгүй асуув.

Голиков холоос эхлэв:

– Би Москвагаас Пенза хавь руу аравдугаар сарын хорин зургаанд гарсан. Арми бүрдүүлэхэд надад хоёр-гурван сар өгсөн...

– Гурван сар! хэмээн Жуков хямсалзав. – Төдий болоход чинь дайн дуусчихаж ч мэднэ. Хэн тийм хугацаа тогтоосон юм?

– Бүрдүүлэх ерөнхий газар гэж Голиков нэр хэлэхгүй зувчуулан хариулав. – Гэтэл би арван нэгдүгээр сарын хорин дөрвөнд нөхөр Шапошниковоос хөдөлгөөнөө эхэлж, арван хоёрдугаар сарын хоёронд Рязанийн хавьд төвлөрөх тушаал авсан.

– Яагаад төвлөрөөгүй байгаа юм?

– Армийг шилжүүлэн байрлуулахын тулд зуун тавин хоёр цуваа хэрэгтэй. Гэтэл ердөө жаран дөрвөн цуваа ирсэн, замд дөчин дөрөв яваа, үлдэх дөчин дөрөв нь ачигдаагүй байгаа.

– Яагаад вагон хөөцөлдөөгүй юм?

– Бид бүх шатны байгууллагад цахилгаан явуулсан. Төмөр замын тээвэр ямар байдалтай байгааг та мэднэ шүү дээ.

– Нөхцөл байдал бүгдээрэнд нь адилхан байгаа. Гэтэл Аравдугаар армиас бусад бүх нөөцийн арми хугацаандаа ирцгээсэн.

Голиков ийм үндэслэлийн хариуд юу хэлэх сэн билээ, дэмий дал мөрөө хавчив.

– Цэргийн бэлэн байдал ямар байна? гэж Жуков эгдүүцэн асуув.

– Цэргийн бие бүрэлдэхүүний жаран таван хувь нь армид алба хаагаагүй хүмүүс. Винтов байхгүй учир модон буугаар сургууль хийсэн байна. Хорооны дөчин хоёр даргын олонхи нь шашны буюу хөдөөний сургууль төгссөн байна.

– Би удирдах бүрэлдэхүүний боловсролыг биш дивизийн байлдах чадварыг асууж байна.

– Арван нэгэн дивизээс наанатай цаанатай байлдах чадвартай нь дөрөв. Бусад нь зэвсэглэж гүйцээгүй, винтов, пулемёт, миномёт, танк эсэргүүцэх буу, танк, хүнд их буу гээд олон юм дутуу. Дивизүүд дулаан хувцас өнөөдөр өртөөнөөс авах ёстой, авсан уу, үгүй юү би мэдэхгүй.

Жуков чимээгүй сонслоо. Бүх арми ингэж л бүрэлдэж байгаа, бүгдээрээ яаж ийгээд болгож байна. Гэтэл энэ нөхөр гомдоллоод сууж байна. Горький, Куйбышевын үйлдвэр заводуос зэвсэг олж чадахгүй, тэнд дулаан хувцас оёулчихаж чадахгүй хүнийг чинь юу ч гэхэв дээ. Улс орон дайнд бэлтгэлгүй байгаа нь үнэн. Голиков өөрөө үүнд буруугүй гэж үү? мань хүн худлаа мэдээлж, Герман довглохгүй гэж нотлоод байсан шүү дээ!

– Дивизийн бие бүрэлдэхүүний бүрдэлт ямар байна?

– Бүрдэлт бүрэн. Дивиз болгон арван нэгэн мянган хүнтэй байгаа.

– Тэгвэл генерал Болдины Тавьдугаар армийн дивиз болгон зургаан зуугаас хоёр мянган хүнтэй, тэд бүтэн сар Тула хотыг хамгаалж, одоо хүртэл алдаагүй цаашид алдахааргүй байна. Одоо ингэж л байлдаж байгаа шүү дээ, нөхөр дэслэгч генерал. Байгаа хүч, хэрэгслээрээ л байлдаж байна. Хэрэв хүрэлцэхгүй байвал өөрснөө олцгоож байгаа.

– Аравдугаар арми тавьсан зорилтыг хэрэгжүүлнэ хэмээн Голиков хөмсөг зангидав.

– Тэгж л найдъя. Танд өөр юу байна?

– Авто хөсөг. Дөнгөж арван хоёр хувь хангагдсан байгаа. Дивизүүд Рязань, Рязскт буугаад, зуу-зуун тавин километр хөдөөний цасанд дарагдсан замаар явган явж байгаа.

– Авто хөсөг Поволжье хавиас олох хэрэгтэй байсан юм.

– Тэнд хуу шүүрдчихсэн байна лээ. Маниас өмнө. Дандаа хуучин юм л үлдэж.

– Хуучныг сэргээх хэрэгтэй шүү дээ. Хэн ч бидэнд шинэ юм өгөхгүй. Байдлыг ойлгох хэрэгтэй, нөхөр дэслэгч генерал... Хэцүү байна. Гэхдээ зургадугаар сарын хорин хоёронд хүлээгээгүй дайсныг хил дээр тоссон хүмүүст олон дахин хэцүү байсан. Та юу гэж бодож байна, дэслэгч генерал?

Голиков битүү санааг ойлгосон боловч сандарч мэгдсэнгүй.

– Тэр ч тэгэлгүй яахав. Гэвч би бол одоо Аравдугаар армийн төлөө хариуцлага хүлээнэ, тийм учраас даалгавар биелүүлэхэд бэлэн байх ёстой.

– Үгүй шүү, дэслэгч генерал, тэнд үлдэгсдийн төлөө та бид нар хариуцлага хүлээх учиртай. Цэргийнхээ байрлалыг харуулна уу.

Голиков цүнхнээсээ зураг гаргаж ширээн дээр дэлгэх зуур,

– Армийн захиргааны хэмжээнд бид хоёрхон зурагтай гэж үг хавчуулав.

Штабын дарга Соколовский орж ирж, Голиков тэр хоёр гар барин мэндлэв.

– Василий Данилович, энэ дэслэгч генерал эднийд зураг байхгүй гэж гомдоллож байна гэж Жуков өгүүлэв.

– Зураг илгээсэн байгаа.

– Захиалгын тухайд?

– Хөнгөвтөр танкийн хоёр батальон, их бууны нэг хороо, миномётийн хоёр батальон өгсөн. Бие бүрэлдэхүүн, суман, батальоныг зэвсгээр гүйцээж хангах ажлыг буулгах өртөөн дээр хийнэ. Одоохондоо өгөх илүү юм байхгүй.

– Авто хөсөг? гэж Голиков асуув.

– Авто хөсөг байхгүй.

– Бидэнд хамгийн багаар бодоход гурав-дөрвөн авто батальон хэрэгтэй. Би энэ тухай Жанжин штабт бичсэн.

– Дэслэгч генерал, таныг элдэв шаардлага, хүсэлтээ фронтын штабт тавьж байхыг хүсье гэж Жуков ширүүлэв. – Батлан хамгаалахын ардын комиссарт хандаж болно, ханд, гэхдээ бас л фронтын штабаар дамжуулж хандах хэрэгтэй. Арми ийм журамтай. түүнийг хэн ч зөрчих ёсгүй.

Жуков зураг руу тонгойв.

– Гудериан Михайловт, танай штаб Шиловт байгаа. Хол явж шүү.

– Штабаа Пронскийн орчим, Старожиловод шилжүүлж байгаа.

– Дивизүүдийнхээ байршлыг заана уу.

Голиков заав. Арми Зарайскаас бараг Скопин хүртэл 120 километр зайд тархан байрласан аж.

– Штабтаа хүрэхэд танд хэдий хэр хугацаа хэрэгтэй вэ?

– Рязань хүрэхэд дөрөв-таван цаг, цаашаа мөн төдийчинээ.

– Одоо яв. Маргааш өглөө дивизийн дарга нараа Пронскийн ойролцоо нэг тосгонд нууцаар цуглуул, та өөрөө найман цагт Пронскт манай хариуцлагатай төлөөлөгчийг биечлэн угтаарай.

Аравдугаар армийн байрлалд хүрэлцэн ирсэн “хариуцлагатай төлөөлөгч” нь Жуков өөрөө байв. Шөнө хоёр хуягт машинтай, хагас суман цэргээр бараа хийн гарсан аж.

түүний явсан тухай штабын дарга Соколовскийгээс өөр мэдэх хүн байхгүй. Ерөнхий жанжны газраас утасдвал “Цэргийн байрлалаар явж байгаа” гэж хариулж байхыг тушаажээ. Сталин командлагч нарт өөрийнх нь зөвшөөрөлгүй өөр фронт руу явахыг хориглодог байж. Өөрийнхөө фронтоор явахыг зөвшөөрдөг боловч дандаа дургүйцнэ, командлагч нарыг утаснаас холдуулахгүй байх санаатай.

Голиковыг, мэдээж, өөрийнх нь зоргонд орхичихож болно. Сталин тавьсан хүнээ хараг гээд. Гэтэл Голиков бүтэлгүйтнэ гэдэг бол сөрөг довтолгоон бүхэлдээ балрана гэсэн үг. Гудериан Баруун фронтын араар ороод ирнэ, тэр сэтэрхийгээр германы явган цэрэг үер мэт сад тавина, энэ бол Москва унана гэсэн үг. Харин одоо бол Гудериан зөөлөн хуурга мэт байна. Хэрээ мэдэхгүй даварч байгаад армия хэт цувуулчихсан, хошуурсных нь яг ар сууринаас цохиж бүслээд, бут ниргэх хэрэгтэй. Аравдугаар армийг албадаж, энэ цохилтыг хийлгэнэ. Шаардлагатай бол урагшгүй дарга нарыг өнөөдөр буудан алахыг тушаана, тэгвэл бусад нь хариуцлагаа мэдрэнэ. Сая саяараа үхэж байхад хэдхэн хүний амь юу юм бэ. Энэ бол Сталины философи, гэхдээ Сталины хүчний эх ундрага энэ ч юм бил үү. түүний ган төмөр мэт эрэмгий зориггүйгээр ийм дайсныг сөрөн зогсох боломжгүй. Сталин уучлашгүй өч төчнөөн алдаа гаргаж, тэр нь ард түмэнд маш их гай удаж байгаа. Гэтэл өөр жолоодогч алга. Тэгэхээр түүнд захирагдахаас өөр яахав. Бас захиргаандаа байгаа дарга нарыг албадан захирах хэрэгтэй. Улс орноо аврах юм энэ л байна.

Жуков машины арын суудал дээр ийнхүү эрэгцүүлэн бодож явав. Дасал болсон бодлууд. тэрээр нэг зүүрмэглэж, нэг сэрж явлаа. Энэ арын суудал дээр олон хоног шөнийг өнгөрөөсөн, олон ч зүйлийг эрэгцүүлж бодсон. Хэзээ мөрөөрөө унтаж хоносноо нэгэнт мартаж. Хаа нэгтээ хоёрхон цаг дуг хийчихвэл бөөн аз! Сталин Кремлиэс үүрээр явдаг болохоор Москвад, Жанжин штабтаа байсан ч шөнөжин сэрүүн хононо.

Машинууд хааяа зогсож, харуулынхан зам чөлөөтэй байгааг илтгэнэ. Тэгээд цааш давхина.

Яг Пронск хүрэхийн өмнөхөн нэг жаахан саад тохиов. Харанхуй хэвээр байгаа ч Жуков хэдийнэ сэрүүн явж байж. Адъютант нь,

– Энд нэг гацаанд баахан машин илрүүлээд, харанхуйд хэнийх гэдэг нь мэдэгдэхгүй, германууд гэж бодсон чинь манайх болж таарлаа, авто суман бололтой юм гэж илтгэв.

– Аль дивизийнх юм?

– Мэдэхгүй, нөхөр армийн генерал. Жолооч нарыг нь сэрээсэн чинь будилаад, авто суман хэнд захирагддагийг хүн ойлгохоор хэлж чадахгүй байна.

– Тэр гацаандаа зогсоцгоо.

Үүр хаяарч, машинууд ч нүдэнд харагдахтайгаа боллоо. Байшин, саравч энэ тэр рүү шахаж тавьсан, заримыг нь хашаан дотор далдалсан маягтай харагдана.

Цаашаа явцгаалаа. Арваад минут яваад зогсов. Пронск руу орох зам дээр тэднийг Голиков хүлээж байж. Жуковыг хараад гайхсангүй, штабын зальжин үнэг, хэн ирэхийг ойлгож байсан учир дөхөж очоод илтгэв: дивизийн бүх дарга нар эндээс холгүй, Пронскоос зүүнтэйхнүүр, Старожиловод цугларсан байгаа.

– Энүүхэнд нэг гацаанд юун машинууд байгаа юм?

– Машинууд аа? хэмээн Голиков гайхав. – Энд ямар ч машин байх ёсгүй. Энд нэг ч дивиз байрлаагүй байгаа.

– Тэнд авто суман байна.

Голиков дал мөрөө хавчив.

– Ёстой мэдэх юм алга.

– Аль нэг дивизийн дарга нуучихсан юм уу? Бас бусад тосгоноор ч нуучихсан байж магадгүй. Гэтэл та тайландаа авто хөсөг байхгүй гэж илтгэж байна.

– Тэр чинь манай машин биш, нэг тэнэмэл авто суман байж магадгүй.

– Танай армийн байршилд байна, тийм учраас та мэдэж байх үүрэгтэй. Учрыг нь олоод илтэг. Нууж байна уу? Далдалж байна уу? Хэн? Хэний тушаалаар? Оргон зайлагчид уу? Хаанаас ирээв? Толгойлогч хэн юм?

Старожиловод хийсэн зөвөлгөөнөө Жуков дараах үгээр эхлэв:

– Та нар тайландаа авто хөсөг байхгүй гэж бичиж байгаа, гэтэл би сая Пронскийн хаяанд авто суман байгааг өөрийнхөө нүдээр харлаа. Тэр суман хэнийх вэ?

Нэг ч хүн дуугарсангүй.

– Хэнийх ч биш болох нь ээ дээ хэмээн Жуков хөмсөг зангидав. – Хэний машин гэдгийн учрыг олно, тэгээд тэдгээрийг нууж байгаа хүмүүсийг хатуу цээрлүүлнэ. Урьдчилан сануулахад: тайланд өчүүхэн төдий худлаа юм оруулбал, зөвсэг, техник нуух юм бол буруутай этгээдийг хатуу шийтгэнэ шүү. Арми бүрэлдүүлэхэд хүрэлцээтэй цаг хугацаа байсан. Та нар одоо фронтод ирчихлээ. Энд байлдах чадвартай дивиз хэрэгтэй.

Энэ ярианы дараа командлагч нарын мэдээлэл Голиковын илтгэлээс шал өөр сонсдож байв. Тийм тийм юм дутуу байгаа, байлдааны ажиллагаа эхлэхээс өмнө авмаар байна, хэрэв байхгүй бол тулалдааны талбараас олзлогыг хичээнэ. Дайчид байлдах зориг төгөлдөр байгаа, коамндлалын тавьсан зорилтыг биелүүлэх болно.

Жуков дивизийн дарга нарыг сонсох хооронд цагаа байн байн харж байв. Ес хагас болчихлоо,

Перхушково руу буцалгүй болохгүй нь. Гэхдээ тэр авто сумангийн явдлыг бүхний нүүрэн дээр учрыг олж дуусгах хэрэгтэй. Хэрэв түүнийг дивизийн дарга нууж байгаа бол түүнийг буулгаж байлдагч болгоно, хэрэв оргон зайлсан суман байгаа бол даргыг нь буудан ална. Аравдугаар армийнханд бүгдэд нь сайн сургамж болно.

– Нөгөө авто суман юу болсон? гэж Голиковоос асуув.

– Тусгайнхан учрыг нь тодруулж байгаа.

– Авто сумангийн дарга руу унаа явуул, нэн даруй ийшээ ирэг.

Удалгүй нүдний шилтэй, бүдүүн хошууч орж ирсэн нь нөгөө тусгай хэлтсийн хүн. Араас нь шинельтэй, даавуу малгайтай, савхин гуталтай, хариугүй зүдэрсэн царайтай, уруул нь омголтсон байлдагчийг оруулж ирэв. Жуков түүн рүү эргэлзсэн янзтай харав.

– Би авто сумангийн даргыг ирүүл гэж тушаасан!

Тусгай хэлтсийн хошууч ёслоод:

– Нөхөр армийн генерал илтгэхийг зөвшөөрнө үү гэв. – Суманд удирдах бүрэлдэхүүн үлдээгүй байна. Хаашаа алга болсон буюу хааш нь алга болгосныг одоогоор тогтоогоогүй байна. Жолооч нар нь тэднийг энэ байлдагч командалж явсан гэж мэдүүлсэн. Тэгээд би энүүнийг байцааж байна. Маш олон зүйл бүдэг бадаг байна, нөхөр армийн генерал.

Жуков Саша руу харав.

– Яагаад илтгэхгүй байна?

Саша гараа өргөн ёслоод нэг юм хэлэхчээн болов. Хоолой нь сөөнгөтөж пэржигнээд, нэг ч үг ойлгогдсонгүй.

– Юу юу гэнэ ээ?! гэж Жуков эгдүүцэн асуув.

– Байлдагч Панкратов хүргэгдэж ирлээ гэж Саша дахин хэлэв.

Жуков түүнийг тогтосхийн харав. түүнд ингэж илтгэж зүрхэлж байсан хүн байхгүй билээ.

Саша түүний харцнаас халирсангүй. Буудан алах уу? Тэгнэ л биз!

– Та суманг командалж явсан уу?

– Би суманг Пронскт дагуулж ирсэн юм.

– Хаанаас?

– Хитрованщина тосгоны хавиас, Михайлов-Павелецийн төмөр замын баруунтайгаас.

– Сумангийн дарга хаа байна?

– Агаарын дайралтын үеэр алагдсан.

– За тэр, дарга нар нь бүгд алагдсан, цэргүүд нь сэвтээ ч үгүй байгаа юм гэж тусгайн нөхөр хажуугаас оров.

– Суманг удирд гэж хэн танд даалгасан юм? гэж Жуков ширүүн асуув.

Саша цугларагсдыг хулганан харав. Генералууд, хурандаа нар, эргэн тойрон сууцгаачихсан, өөрийг нь харцгааж байна. Ромботой, элдэв мөрдөстэй, малилзсан амьтад... Эд нарыг одоо тийш нь цас руу, жалга руу явуулж, машин чирүүлэх юм сан... Стратегичид... Улс орныг ийм болгочихоод... Гитлерийг Москва руу ирүүлчихээд... Эд нарын тухай бодож байгаагаа хуу хэлчих юм сан...

– Суманг удирд гэж хэн танд даалгасан юм бэ?! гэж би асууж байна.

Бас энэний байж байгааг! Алдарт жанжин гэсэн чинь бас байцаалт явуулж байна.

– Хөөе! хэмээн Жуков дуу нь чангараад явчихав.

– Эх орон маань даалгасан, нөхөр армийн генерал гэж Саша сөөнгөтүүлэв.

Бүгд дуу алга, генералууд ч, хурандаа нар ч.

Жуков Сашаг ширтэн харж байна.

– Та намын гишүүн үү?

– Нам бус.

– Пронск яаж яваад ирчихэв?

– Манай суман Хоёр зуун гучин есдүгээр дивизийн ар тал руу, Узловая өртөө рүү ачаа хүргэх ёстой байсан юм. Хэдэн цэрэгтэй нэг ахмад тааралдаад, дивиз бүслэгдсэн гэж хэлсэн. Тэгвэл яах вэ? Германы танк Михайлов, Скопин хоёр руу явж байгаа. Бидний хувьд цорын ганц зам нь Михайлов, Скопин хоёрын завсраар байсан юм.

– Тэнд чинь зам байдаг юм уу?

– Дагтаршуулсан далан бий.

Жуков зураг руугаа тонгойв.

– Энд юу ч тэмдэглээгүй байна.

– Тэр замыг дайны өмнө барьж байгаад дуусаагүй юм. Даланг л дагтаршуулж амжсан. Зураг

дээр, мэдээж, байхгүй.

– Та тэр даланг яаж мэдэж байгаа юм?

– Би энэ замыг тавих ажилд оролцож байсан юм.

– Зураг дээр зааж чадах уу?

Саша зураг руу тонгойтол, дулаан өрөөнд малгайных нь цас хайлснаас нэг дусал дусчихав.

– Малгайгаа авахыг зөвшөөрнө үү, зураг норгочих нь.

– Авч болно.

Саша малгайгаа сугавчлаад, зураг руу дахин тонгойв.

– За энэ суурингуудаар: Дурное, Грязное, Малинки, Хитрованщина.

Жуков штабын дарга руу зургийг дөхүүлж,

– Өөрийнхөө зурган дээр тэмдэглэж ав гэснээ Саша руу эргэж, – Замын байдал ямар байна? гэж асуув.

– Бид хүрдэж байж тууллаа. Цас цэвэрлэх машинтай бол явчихаж болно.

– Хичнээн болов?

– Хоёр хоног. Өдөр бөмбөгдөхөөс айгаад, шөнөөр л явлаа.

– Одоо ч шөнө урт даа хэмээн Жуков бодлогошрон өгүүлээд, – Хохирол? гэж асуув.

– Нэг шархтан байгаа, осгосон хүмүүс бий. Эмнэлгийн тусламж үзүүлэхийг хүсье гэснээ Саша хошууч руу хяламхийв. – Иргэн хошууч биднийг гэмт хэрэгтэн гэж нэрлэсэн хэдий ч, гэмт хэрэгтэн ч эмнэлгийн тусламж авах эрхтэй.

– Тусламж үзүүлнэ гэж Жуков өгүүлээд, – Та Хоёр зуун гучин есдүгээр дивизийн командлагчийн овгийг мэдэх үү гэж асуув.

– Мэдэхгүй.

– Хурандаа Мартиросьян! хэмээн тэр дивизийн дарга, залуухан, гоё армян босов.

– Хурандаа Мартиросьян, таны авто суман уу?

– Нөхөр армийн генерал, илтгэхийг зөвшөөрнө үү, манай дивизийн мэдэлд ирэхээр ачаа хүргэх тусгай авто суман явж байсан. Гэтэл дивиз маань манайхыг бүсэлсэн, биднээс хүчээр давуу дайсантай нэгэнт байлдаад эхэлчихсэн байсан, тэгээд арван нэгдүгээр сарын хорин долоонд бид хүнд техникээ ойд газар ухаж нуугаад, бүслэлтийг сэтлэн, ийшээ, “Большое

село”-гийн хавьд ирсэн. Бүслэгдсэн дивиз рүү авто суман ирж чадахгүй байсан. Энэ авто суманг чухамхүү тэр суман гэж үзэх үндэс байна.

– Танд хаанаас тийм үндэс байна?

– Бүх байдал давхцаж байгаагаас тийм болж таарч байна, нөхөр армийн генерал. Хэрэв та ярихыг зөвшөөрвөл...

– Ярьж болно!

– Хэрэв та ярихыг зөвшөөрвөл, нөхөр армийн генерал хэмээн Мартиросьян давтан өгүүлээд, – Энэ суман довтолж байгаа танкийн хоёр армийн дундуур явж Пронскт ирснийг цэргийн үүргээ эрэлхэгээр биелүүлсэн явдал гэж үзэж байна гэв.

– Уухайс, тийм байх нь уу гэж Жуков мушилзав. – За яахав, та суу! Байлдагч...

– Панкратов гэж тусгайн хошууч хэлж өгөв.

– Панкратов... Та зураг уншдаг юм байна. Хаана сурч байв?

– Москвагийн авто тээврийн дээдийн авто замын салбарт.

– Тэгвэл инженер байх нь... Яагаад байлдагч яваа юм?

– Ингэж л таарсан юм.

– Боловсролын тухай бичиг баримт байна уу?.. Үзүүл!

Саша шинелийнхээ товчийг тайлж, цэрэг цамцныхаа халааснаас дөрөв нугалсан гэрчилгээгээ гаргаж ширээн дээр тавив. Зайлах газар алга! Муусайнууд мэдэж аваг л дээ, яадгийм. Фронтоос хол цөлөх газар байхгүй.

Жуков эхний нүүрийг уншаад эргүүллээ... Саша түүнийг хараа салгахгүй харж байв... Одоо: “Баригдсан учраас дипломын төслөө хамгаалаагүй...” гэдэг мөрийг хүрнэ. Хүрлээ! Саша руу харлаа... Дахиад уншлаа, дахиад харлаа...

– Комсомолын гишүүн байсан уу, хэдэн оноос?

– Хорин таван оноос.

Жуков гэрчилгээ рүү дахин харав.

– Энд цэргийн явдлын хичээлийг тооцсон гэж байна.

– Манай сургуульд цэргээс гадуурх цэргийн дээд бэлтгэл байсан.

Жуков Голиков руу эргэв.

– Манайд инженер хүрэлцэхгүй байгаа, гэтэл танайд зүгээр жолооч хийгээд явж байдаг юм байна.

Голиков энэ авто сумангийн талаар мэдэх юм байхгүй, энэ жолоочийг анх удаагаа харж байна гэж хэлж болох байсан. Гэвч тэрээр туршлагатай түшмэл учраас ийм үед зөрж болохгүйг ойлголгүй яахав. Жуковын зөв: инженерийн боловсон хүчнийг ингэж ашиглана гэдэг бол зүй бус явдал, зүй бус явдлын төлөө хэн нэгнийг донгодох хэрэгтэй, чухам хэнийг гэдэг нь падгүй асуудал.

Жуков Сашагаас цэргийн батлахыг нь авч штабын даргад шилжүүлээд, гэрчилгээг нь харж байгаад:

– Нэмэгдэл өгөгдөхүүнийг бичээд ав. 1934 онд авто замын салбар төгссөн. Гэрчилгээний дугаар зуун наян зургаа, ташуу зураас, гучин дөрөв... Бичив үү? Гуравдугаар зэргийн цэргийн техникчийн цол олгохоор давтан шалгалтын дүгнэлт гарга, би түүнийг чинь одоо батлана гэв.

Сашад гэрчилгээг нь буцааж өгөв.

– Гуравдугаар зэргийн цэргийн техникч цол авсанд баяр хүргэе.

– Баярлалаа, нөхөр армийн генерал.

– Ажиллаад бай, байлдаад бай, Зөвлөлт Холбоот Улсын төлөө зүтгээд бай.

Саша ёслон,

– Зөвлөлт Холбоот Улсын төлөө зүтгэе! гэв.

Арван хоёрдугаар сарын 6-ны өглөө зөвлөлтийн цэрэг сөрөг довтолгоонд орж, хэдийгээр айхтар жавартай, цас ихтэй байсан боловч дайсны цэргийг Москвагаас 150-200 километр ухрааж хөөлөө.

Радиоогоор сүрлэг хөгжим хангинаж, хагас цаг болгон германы цэргийн эрчимтэй давшилтын тухай, эзлэгдсэн хотууд, сөнөөсөн онгоцнууд, хэдэн зуун мянган олзлогдогсдын тухай мэдээлж байна: “Зөвлөлтийн цэргүүд хөл мэдэн зугтаад бид араас нь амжихтай үгүйтэй байна”. Цагаачдын сонингууд: “Бидний цаг ирлээ” хэмээн баяр болцгоож байна.

Герман Европын бусад улсыг нүд ирмэхийн зуур ялсан шигээ Оросыг бас тэгж ялна. Одоо мань Шарокт юу гээч тохиодог бол? Берия өөрийнхөө байгууллагын бичиг баримтыг устгаж амжих болов уу, яах бол? Хэрэв амжихгүй бол, германууд өөрийнх нь ар талд, Парист ноён Привалов гэдэг зөвлөлтийн тагнуул байгааг илрүүлнэ. Амжиж устгалаа ч гэсэн ДЯАК-ын ажилтнуудыг барьж авна, тэд нар нь хар амиа аврах гэж түүнийг илчлэнэ. Аль ч тохиолдолд мань хүн дүүжлүүрийн шонгоос зайлахгүй нь.

Яах болж байна аа? Германууд руу очиж улайдаг юм уу? Тэд нар өөрөөр нь яах вэ дээ? Өөрөө хэн юм бэ? Зөвлөлтийнхний Өрнөдөд хаясан тагнуул. Өөрийгөө: “Германы эсрэг ажиллаагүй, цагаан гвардийн цагаачдын эсрэг ажиллаж байсан” гэж зөвтгөх гэж үзнэ. Гэвч хэн түүнийг сонсох вэ дээ?

Англичуудыг дагаад зугтчих уу? Юутай тэр билээ? Тэдэнд хэнийг илчилж өгөх вэ? Третьяковыг уу? Тэдэнд Третьяков ч хэрэггүй, Шарок ч хэрэггүй. Гитлерийн эсрэг үнэнч холбоотон нараасаа үүнийг аваарай гээд заяагүй урвагчийг ЗСБНХУ-д тушаачихна.

Аль гучин есөн онд л зугтах хэрэгтэй байж. Тэгэхэд бол гар хоосон биш, тагнуулын суурин ахлагч, тагнуулууд, нууц уулзалтын газар, Эйтингон, Мексикийн багийнхантайгаа энэ тэр гээд том олзтой очих байсан. Нэмэрт нь хол явахын хэрэг байгаагүй, тэдний сөрөг тагнуулын салбар хажуугийн гудамжинд байсан юм чинь.

Германуудыг Москвагийн хаяанд зогсоосон нь Шарокийг бага зэрэг тайвшруулав. Шууд эзэлж чадаагүй болохоор ДЯАК баримт бичгээ устгах буюу аваад явж амжина, тэгсэн байхад ноён Приваловын тухай үлгэр тэгтлээ түргэн илрэхгүй.

Шарок бүх насаараа зөвлөлт засгийн өмнө бэмбэгнэж, энэ засаг юунд ч дийлдэшгүй гэж бат итгэж явсан. Тэгтэл одоо ингээд түүний ялагдлыг бах таваа ханган ажиглаж байна. Гэтэл энэ дэглэм унах юм бол гэмт хэргийнх нь хариуцлагыг өөрөө ч хүлээлцэх ёстой болно, энэ засагтай үүрд хүлэгдсэн юм чинь. Тийм учраас тэр засаг тэсч байзнавал дээр сэн, тэгж байтал байдал мэдэгдэнэ биз. Одоохондоо бол зөв шугам баримталж байх хэрэгтэй...

Дөчин хоёр оны хоёрдугаар сард гудамжинд явж байтал нэг хүн Шароктой зэрэгцээд иржээ. Таяг, пальто, бүрх малгай энэ тэр нь ч яахав, зориуд яаж алхаагаа сааснаар нь Шарок аюулыг мэдэрч, зайлсхийж хармагц хамаг бие нь хүйт оргиод явчихжээ. Нөгөө Троцкийн хүү Лев Седовыг алахаар Парист ирж байсан “Алексей” өөдөөс нь харж байх нь тэр. Франц хэлнийх нь мэдлэгийг Шарок тухайн үедээ бишрэн гайхаж асан, хуучин боксчин нөхөр. “Алексей” ямар тусгай даалгавар биелүүлдгийг Шарок мэднэ. Яков Серебрянскийн бүлгийнх. Гэтэл газрын хаанаас энд гараад ирэв?! Серебрянский өөрөө ч, “Яшагийн хөвүүд” ч бүгдээрээ аль хэдийнэ алуулцагасан. “Алексей” францаар,

– Жерар Дюраль, эсвэл зүгээр “месье Жерар” гээд гараа өгөв.

Тэр хоёр кафед орж, буланд суугаад кофе захив. Тэнд хүн байхгүй, эзэн нь лангууныхаа ард ойр зуурын ажлаа хийж байна.

– Яагаад сандарчихав, хэн ч ирэх ёсгүй байсан юм гэж үү? хэмээн “Алексей” францаар асуугаад, цаашаа тэр хоёр францаар ярилцав.

Шарокийн айдас нэг л сайн арилж өгдөггүй. Гар буугаа ганцхан сугалж буудчихаад, дараа нь эзнийг бас тонилгочихоод алга болчих юм бил үү. Пальто, малгайгаа тайлаагүй, бэлэн сууж байгаа, цонх, хаалганы эсрэг талд суудал сонгосон, эзэн хажуу талаасаа илхэн байна, хоромхон зуур амжуулчихна.

Шарок “Алексей”-гаас хараа салгалгүй,

– Яков Исаковичийг, бас түүний бүлгийг бүгдийг нь шоронд хийсэн юм шиг би дуулсан гэж хариулав.

“Алексей” кофеноос нэг балгаад аягаа ширээн дээр тавив.

– Тэгэхэд надад арван жил өгсөн, бусдыг маань буудан алсан. Яков Исаковичийг, яагаад ч юм, яах гэж яарахгүй байж, алуулах ялтны өрөөнд хориотой хоногоо хүлээж байсан нь түүнийг аварсан байна лээ. Дайн эхэлтэл, “эзэн” “манайхнаас” түүнийг сураглан: “Серебрянский хаана байна?” гэж. — “Буудан алахыг хүлээгээд шоронд сууж байгаа”. Эзэн: “Юу гэж донгосоод байгаа юм?” гэж. Тэгэнгүүт “манайхан” шорон руу бушуухан харайлгаж, түүнийг гаргаж аваад, сувилалд явуулж. Ежовын барлагууд түүнийг элэг бөөргүй болгочихгүй юу.

тэрээр кофеноосоо дахин балгав, ашгүй, аягаа барьж байна.

– Яков Исакович бүлгээ буцааж өгөхийг шаардсан чинь үлдсэн нь ганц би байж. Тийм сайхан багийг устгачихсан, Ежов тагнуулын албыг сөнөөчихсөн, муу архины лүү, бандидагч балай!

“Алексейн” ярьсан юм нь биш, ийм илэн далангүй байгаа нь Шарокт хачин санагджээ. Нөхөр Сталины тухай “эзэн” гэж, бас Берия, Судоплатов энэ тэрийн тухай “манайхан” хэмээн чөлөөтэй ярьж байна... Яагаад ингэж байгаа юм бол? Өөрийнх нь сонор сэрэмжийг алдуулж байгаа юм биш биз?!

“Алексей” гэнэт жуумалзав:

– Гар руу хараад байх чинь, чиний бодийг хөтлөх гэж явна гэж санаа юу?

– Намайг яасан гэж тэгэх билээ? хэмээн Шарок худлаа инээв.

– Намайг яасан гэж тэгсэн билээ? гээд “Алексей” нүдээ онилгов.

– Зүв зүгээр байхад чинь л тэр гэж Шарок бушуухан өчив.

– Харин, тэгж яривал, чамд бол юм яг байгаа шүү.

– Алексей, чи юу ярина вэ? гээд Шарок бүр өндөсхийв.

– Би чамд Жерар гэж нэрээ хэлсэн шүү.

– Өршөөгөөрэй, Жерар, чиний юун тухай ярьж байгааг би ойлгохгүй байна.

– Чи чинь намайг барьцаанд өгсөн шүү дээ, тийм биз дээ?

– Би юү? Чамайг уу?

– Тийм, чи намайг. Седовын хэргээр.

Москванд бичсэн тайлбар бичиг хоромхон зуур санаанд нь тодроод ирлээ.

– Би юу болсныг л зөвхөн баримтаар бичсэн, ямар ч үнэлгээ дүгнэлт байхгүй.

– Ямар ч үнэлгээ дүгнэлт байхгүй ээ? “Ирсэн, үйлдлээ хийсэн, тэр үйлдлийн үр дүнд маш чухал мэдээллийн эх сурвалжийг үнэгүйдүүлсэн” – энэ чинь дүгнэлт биш юм уу?!

Ээ чөтгөр алгад гэж! Энэ өгүүлбэрийг бичих үү, яршиг уу гэж тэгэхэд өөрөө эргэлзэж байсан нь дэмий биш байж. Совин татсан юм шиг.

“Алексей” кофегоо гүйцээж уугаад, аягаа ширээн дээр тавив.

– Хуучныг дурсахаа больцгооё. Төвийн шийдвэрийг уламжлая. Чамайг батлан дааж германуудад үнэмшүүлж чадах цагаачдын итгэлийг чи олох ёстой. Бусад бүх юм аяндаа зохицуулагдана. Зорилго нь Заксенхаузений хорих лагерийн ойролцоо, Ораниенбургт байдаг Хорих лагериудын төв захиргаанд орчуулагчийн албанд орох явдал. Тэнд Заксенхаузен гэдэг зуслангийн суурин байгаа, лагерийг түүгээр нэрлэсэн юм билээ. Лагериудад манай хэдэн зуун мянган олзныхон байгаа, бид тэдний талаар мэдээлэлтэй байх ёстой гээд тэрээр,

– Чиний хэл чинь ямар билээ? гэж германаар асуув.

– Дажгүй л гэж бодож байна. Чи чинь бас герман хэлтэй юм уу?

– Би франц, герман, англи, испанийг мэднэ. Тухайн үедээ манайд зөвхөн хэлтэй улсыг авч байсан юм.

Өөрийгөө Ежовын устгасан жинхэнэ чекистүүдийн нэг, Шарок бол шинэчүүдийн нэг гэдгийг цохон хэлж байна. Энэ хүнтэй муудалцах аюултай учраас Шарок битүү санааг нь ойлгоогүй дүр исгэн, шүлсээ залгиад өнгөрөв. Ер нь ч худлаа ярьж байгаа нь мэдээж, “олон зуун мянган олзныхны” тухай мэдээлэл түүнд хэрэггүй. Тэр бол олон зуун мянгыг биш, тухайлсан хүмүүсийг хариуцдаг хүн, түүний ажил бол хулгайлж устгах. Энэ удаа Заксенхаузенд хэнийг устгах гэж байгаа нь Шарокт падгүй, түүнд мэдээлэл цуглуулахыг даалгаж байна, мань хүн түүнийг нь л цуглуулах болно.

– Намайг энд байх хооронд надтай л холбоо барина, би Парист Швейцарын худалдааны пүүсийг төлөөлж байгаа. Намайг байхгүй үед хэрэг гарвал чам дээр хүн ирнэ. Чиний энэ үүргийг Төв ихэд чухалчлан үзэж байгаа, хэцүү гэдгийг ойлгож байгаа, гэхдээ чамд ихээхэн найдвар тавьж байгаа, ажлыг чинь зохих ёсоор үнэлэх болно хэмээн “Алексей” яриагаа төгсгөв.

Шарок өөрийн эрхгүй “дагз руу л сум зоож үнэлэх вий” гэж боджээ.

Сталин гуравдугаар сард нэг удаа Васильевскийгээс,

– Та нүүлгэн шилжүүлсэн гэр бүлээ буцааж авчирсан уу? гэж асуужээ.

– Авчирсаан, нөхөр Сталин.

– Тэд чинь хаа аж төрж байна?

– Надад Грановскийн гудамжинд сайхан байр өгсөн.

Сталин түүн рүү эгцлэн харж,

– Грановскийн гудамжинд аа? Зөвлөлүүдийн Тавдугаар байшинд уу? гэв.

– Тийм, нөхөр Сталин, хуучин тийм нэртэй байсан юм билээ.

– Би тэр байшинг мэднэ, нэг үе орж гардаг байлаа гэж Сталин бодлогошрон өгүүлээд, – Таны эцэг эх чинь хаана байгаав? гэж асуув.

– Эх маань нас барсан, эцэг Кинешмад, миний том эгч дээр байгаа. түүний нөхөр, хүү хоёр нь фронтод яваа.

– Тэгвэл нөгөө хийдээ орхио юу?

– Орхисоон, нөхөр Сталин, манай дүү нар, бид хэд эцэг, эгч хоёрт туслаж байгаа.

– Тэгэхээр Грановскийн гудамжинд суудаг байх нь, болж байна. Амрах боломж гарвал хаа амарч байна?

– Жанжин штабтаа. Миний албан тасалгааны хажууд нэг өрөө бий, тэнд унтчихдаг юм.

– Танд зуслан байхгүй юү?

– Байхгүй ээ, нөхөр Сталин.

Васильевский хэд хоногийн дараа Сетунь голын эрэг дээр, Волыньское сууринд Сталины Ойрын зуслангаас холгүй зуслантай болсон ч тийшээ очих нь ховор, хааяа хоновол үүрээр ажил руугаа яваад өгнө.

Нэг удаа цэцэрлэгт авгайдаа нэмэр болж түр саатаад яг явах гэж байтал Поскребышев утасдаж,

– Таныг нөхөр Сталин хайж байна.

Тэгээд утаснаас Сталины дуу гарч,

– Нөхөр Васильевский, та зуслан дээрээ төвхнөж амжаагүй хэрнээ явахаа үзэхгүй суучихдаг бол оо шив. Тийшээ бүүр нүүчих вий гэж би айж байна шүү. Даруйхан хүрээд ир гэв.

Ерөнхий жанжны газрын хурал эхэлчихсэн байхад Васильевский ирэв. 1942 оны зуны цэргийн ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж байжээ.

– Германууд Москва орчимд ялагдаад сэтгэл санаа алдарсан учир одоо амсхийж, хүчээ сэлбэх санаатай байна хэмээн Сталин эхлэв. – Бид тэдэнд амсхийх цаг өгч болох уу? Болохгүй. Тэдэнд хүчээ сэлбэх боломж олгох эрх бидэнд бий юү? Бидэнд тийм эрх байхгүй.

Шапошников, өвлийн ажиллагааны явцад манай хүч ихээхэн сульдсан, довтолгоо хийхэд хараахан бэлэнгүй байна гэж үгээ болгоомжтой эвлүүлэн өгүүлэв.

– Германуудыг аль болох түргэн хиар цохих хэрэгтэй, зогсоо чөлөөгүй элдэх хэрэгтэй, зай завсаргүй, сөгөө өгөхгүй элдэх хэрэгтэй. Тийнхүү, германуудыг 1942 онд бүрмөсөн бут цохих нөхцлийг хангах хэрэгтэй. Хэн юу хэлмээр байна?

Германуудыг энэ онд бүрмөсөн бут ниргэх тухай ярих нь утгагүйг бүгдээрээ ойлгож байв. Гэвч хэн ч бодлоо хэлэхийг хүссэнгүй. Жуковоос өөр хэн ч.

– Бэлтгэлгүйгээр, цэргээ техник болон амьд хүчээр бэхжүүлэхгүйгээр довтлох боломжгүй гэж Жуков хэлэв.

– Бид германуудыг эхэлж цохилт өгөхийг хүлээгээд, хамгаалалтанд гар хумхиад сууж байхгүй биз дээ! гэж Сталин унтууцах маягтай хэлэв. – Үгүйдээн өрсөх цохилт хэдэн удаа хийж, дайсан хэр бэлэн байгааг тандах хэрэгтэй.

Тимошенко Харьковын чиглэлээр тийм цохилт хийхийг тэр дор нь санал болгов. түүнийг Ворошилов дэмжив. Жуков зөрөх гэж үзсэн боловч Сталин урдуур нь оров:

– Байзаарай, алив байзнаарай... Бид германуудыг хаагуур довтлоно гэж хүлээж байгаа билээ? гээд бүгдийг нь асуух маягтай харав. – Энэ зун тэд нар хаагуур довтлох вэ? Ганцхан хариу байгаа: тэд нар Москва руу дахиад дайрах нь гарцаагүй. Яагаад? Яагаад гэвэл Москва ойрхон байна. Москва руу довтлох тухай фельдмаршал Клюге-гийн тушаалыг манайхан завсраас нь олзолж сонссон. Тэр ажилбар “Кремль” гэдэг нууцалсан нэртэй. Бид түүнд бэлтгэх ёстой. Гэхдээ энэ маань германы хүчийг хөдөлгөхгүй барихын тулд жигүүрээр хүчтэй цохилт өгч, тэгснээрээ Москва руу хийх довтолгоог сулруулах ёсгүй гэсэн үг биш. Тэгэх ёсгүй биш, харин ч тэгэх ёстой. Эхний ээлжинд тийм цохилтыг хаагуур өгөх вэ? Нөхөр Тимошенко, нөхөр Ворошилов хоёрын зөв гэж бодож байна. Харьков руу довтлох саналыг дэмжих нь зүйтэй.

Тагнуулын мэдээгээр германы цохилтын чиглэл нь өмнөд нутаг байх болно гэж Васильевский хэлж болох байв. Гэвч тэрээр Сталинтай зөрөхөөс дандаа айдаг, одоо бол хоцорч зэм дуулсандаа бантаад хурлыг дуусан дуустал дуугарсангүй.

түүний оронд Жуков хариулав:

– Нөхөр Сталин, германууд гол довтолгоогоо өмнөд чиглэлээр хийнэ гэсэн тагнуулын мэдээ байгаа. Клюге-гийн тушаалыг төөрөгдүүлэх мэдээ гэж үзэж болно. Яаж төгсөх нь эргэлзээтэй ажилбарт цэргээ татан оруулж болохгүй...

– Эргэлзээтэй гэнэ ээ?! хэмээн Сталин үгий нь тасдав. – Яагаад эргэлзээтэй гэж? Нөхөр Тимошенко, та ажилбар амжилттай болно гэж итгэж байна уу?

– Итгэлгүй яахав.

– Энэ чинь таны хувийн бодол уу?

– Үгүй, фронтын бүх удирдлага тэгж үзэж байгаа.

– Юу болж байгааг хараа биз, фронтын удирдлага амжилт олно гэж итгэж байхад, нөхөр Жуков эргэлзэж байна. Энэ тохиолдолд фронтын удирлагын бодол илүү үндэслэлтэй гэж бодож байна.

Өрөөнөөс гарч яваад Шапошников Жуковт,

– Та дэмий маргалаа. Энэ асуудлыг Ерөнхий өөрөө шийдсэн юм.

– Тэгвэл яах гэж бидний бодлыг асуусан юм?

– Би яаж мэдэхэв, хонгор минь.

Харьковын чиглэлээр тавдугаар сарын 12-нд довтолж эхлэв. Энэ довтолгоо явцгүй нь долоо хоногийн дараа илэрхий болов. Жанжин штабын даргын үүрэг гүйцэтгэгч Васильевский довтолгоог зогсоохыг Сталинд санал болгов. Гэвч Сталин шийдвэрээ өөрчилж заншаагүй билээ. Тавдугаар сарын 29-нд уг довтолгоо сүйрч төгсөв. Бүслэгдсэн зөвлөлтийн дөрвөн армиас алагдсан, олзлогдсон хүний тоо нийтдээ 230 мянгад хүрчээ. Тулалдаанд Костенко, Подлас, Бобкин нарын генерал амь эрсэджээ.

Сталин германуудыг ноднин өмнө зүгээр довтолно гэж тооцоолоод алдсан бол энэ жил Москва руу довтолно гэж тооцоолоод алдлаа. Германууд Крым, Севастополийг эзэлж, зөвлөлтийн цэргийг Донын цаад руу хөөснөөр Кавказ, Сталинградын зүг эрчтэй давшиж эхлэв.

Сталин долдугаар сарын 2-нд 227 тоот тушаал гаргав:

“Бид 70 сая гаруй хүн амаа алдлаа... Цааш ухрана гэдэг бол өөрсдийгөө, үүний хамт эх орноо хөнөөнө гэсэн үг. Ганц алхам ч бүү ухар! Торгуулийн батальон эмхлэн бүрдүүлж, тийш нь дунд болон ахлах тушаалын дарга нарыг илгээх. Тэдгээр батальонихонд эх орныхоо өмнө хийсэн гэмт ялаа цусаараа цайруулах боломж олгохын тулд тэднийг фронтын хамгийн хүнд хэсгүүд дээр тавих... Сайтар зэвсэглэсэн хориглон тогтоох отрядууд байгуулж, тогтворгүй дивизийн ард байрлуулах, тэдгээрт, цэргийн ангиуд балмагдан сандарч, эмх замбараагүй зугтвал тийм балмагдсан этгээд, хулчгаруудыг газар дээр нь буудаж байх үүрэг оногдуулах”.

Энэ тушаал дарга нарын санаачлагыг боогдуулж, элдэв арга хэрэглэх боломжийг чөдөрлөн, утга учиргүй гарз хохирлыг ихэсгэжээ. Энэ тушаалыг биелүүлнэ гэдэг бол армийг арга буюу ялагдахад хүргэнэ гэсэн үг болжээ. Германууд тэртэй тэргүй урагшлан ахиж, Майкоп, Краснодар, Моздокийг эзэлж, Терек гол руу гарснаар, Өвөр Кавказ руу зам нээгдэх бараг бүх давааг мэдэлдээ оруулжээ. Гэхдээ дайсанд олзлогдох, зэвсэг техникээ олзлуулах явдал гарахаа больсон байна. Зөвлөлтийн цэрэг Сталины тушаалыг зөрчин, ухрах давшихыг хослуулан, бүслэлтэнд орохгүй, чадварлаг байлдаж байв. Гагцхүү фронтын нарийнхан хэсгээр Паулюсын арми наймдугаар сарын 23-нд Сталинградын баруун хаяа руу хүрч чаджээ.

Улс орон нь хоёр хэрчигдэж байгааг Сталин маш сайн ойлгож байв. Гитлер өмнөд нутгийг тэр чигээр нь, Украин, Кавказ, Өвөр Кавказыг эзэгнэж байна. Гэвч гол нь Сталинград! Германууд манай цэргийг Волга руу шахан, хотыг хазуур шиг зууж авлаа. Хэрэв Сталинград унавал Зөвлөлтийн Европын хэсгийн усны гол судас германы гарт орчихно. Тэд Сталинградаас хойш эргэж, Москвагийн ар худрагаар орно, тэгсэн цагт Улаан Армийн үндсэн хүч торонд орсон мэт болно. Сталинградын хавьд одоо хамгийн шилдэг жанжнууд байгаа. Тэгсэн ч гэсэн тэнд Жуков хэрэгтэй. Жуков бол түүний хувьд урьдын адил найдвартай байдлын биелэл болж байгаа цорын ганц хүн. Васильевский ажил явдлын учрыг олдог хүн, гэхдээ онцгой нөхцөлд зөөлдөнө. Онцгой нөхцөлд Жуков хэрэгтэй. Гитлер нөхөр Сталины бодож байсан шиг Москва руу дайраагүй, Жуковын хэлж байсан шиг өмнө зүгээр довтолсон учраас Жуков, мэдээж, өөртөө эрэмших зан нь оодорсон. Тэгэхээр стратегич нь нөхөр Сталин биш, мань Жуков гэсэн бодол нь батажсан байгаа. Нөхөр Жуков эндүүрч байна! Харьковын тухай яригдаж байхад, финнийн дайныг балласан муу тээрхий Ворошиловын үгэнд орох ёсгүй байсан байж магадгүй. Бас Тимошенкогийн үгэнд орох ч хэрэггүй байж. түүний албаны зам үүгээр дуусна, гэхдээ Жуков ч гэсэн нэг их хөөрөхийн хэрэггүй. тэрээр Жуковт байх ёстой газрыг зааж өгнө. түүний байх газар бол цэргийн байрлал, фронт, тэнд мань хүн амжилт олж чадна. Тийм учраас Сталинград руу яваг. Гэхдээ бас урмаар тэтгэх хэрэгтэй.

Жуковыг наймдугаар сарын 26-нд Баруун фронтын штабт байхад нь Москва руу дууджээ.

Сталины өрөөнд түүнийг ороход урьдын адил Молотов, Ворошилов, Берия гурав сууж байв.

Сталин Жуковыг ширээ рүү суухыг урив. Цай, хачиртай талх оруулж ирлээ.

– Ингэхээр, Гитлер алдаагаа засахаар шийдэж гэж Сталин санаанд оромгүй юм хэлэв.

Жуков түүн рүү гайхшран харав.

Сталин хачиртай талх руу зааж,

– Ид, ид, та өлсөж яваа байлгүй гэв.

Тэгээд босч өрөөн дундуураа алхах зуур ярьж эхлэв.

– Гитлерийн өнгөрсөн жилийн гол стратегийн алдаа юунд байв? Гол хүчээ Москва руу хаясанд байсан, Гитлер өмнөд чиглэлээр давшиж, тариа, металл, нүүрс, газрын тос энэ

тэртэй болж, Украин, Кавказ, Өвөр Кавказын үндсэрхэг үзэлтнүүдийг өөрийнхөө талд татах ёстой байсан. Тэгж байж энэ жил Москва руу баруун, хойд, өмнө талаас давших учиртай байлаа л даа. Тийм стратегийг бид хүлээж байсан. Гэтэл муу тоглогчтой тоглохоор чинь аль хэзрээрөө гарахыг нь хэзээ ч мэдэх арга байхгүй юм. Гитлерийг гашуун туршлагаасаа сургамж авч, энэ жил зөв нүүдэл хийнэ, ойрхон байгаа Москва руу бөөн хүчээр дайрна гэж бид бодож байлаа. Тэгсэн чинь үгүй шүү, өмнө чиглэлээр довтлохоор шийдэж. Гэтэл өнгөрсөн жилийн хувьд зөв байсан юм нь энэ жилийн хувьд бол буруу. Гитлер адтай боловч муу тоглогчийн хувьд биднийг дахиад залилчихлаа. Тэр зарим нэг амжилт олж, Сталинград хүрлээ. Гэхдээ энэ бол түр зуурын амжилт, муу стратегич хүнд эцсийн амжилт гэж байх ёсгүй. Гитлерийн түр зуурын амжилтыг хийх хэрэгтэй. Бид түүнийг Москвагийн хаяанд зогсоосон шигээ Сталинградын хаяанд бас зогсоох хэрэгтэй.

Сталин Жуков руу дөхөж очоод, буурьтай бараг ёслол төгөлдөр гэмээр ийн өгүүлэв:

– Нөхөр Жуков! Улсыг Батлан Хамгаалах Хороо таныг Дээд Ерөнхий командлагчийн орлогчоор томилж байна.

Жуков босч номхон зогсов.

– Баярлалаа, нөхөр Сталин.

– Та Сталинградын дүүрэг рүү нэн даруй очвол зохино. Германуудыг бут цохих хэрэгтэй, ноднин Москвагаас хөөсөн шиг хөсөр хөөх хэрэгтэй.

Сталин Жуковт гараа өгч,

– Замдаа сайн яваарай! Нөхөр Жуков танд амжилт хүсье! гэв.

Варягийн ажиллаж байгаа Хамгаалалтын байгууламжийн удирдах газрыг Москвагаас Саратов хавь руу шилжүүлжээ. Гитлерийн цэрэг Сталинградыг эзлэх юм бол хойшоо эргэж довтолно, тийм учраас тэдний давшиж магадгүй замд хамгаалалтын байгууламж барьж байсан юм.

Удирдах газрын штабыг хуучин Бүгд найрамдах Поволжье-гийн герман улсын нутаг дэвсгэрт, Байдек сууринд байрлуулжээ. Дөчин нэгэн оны наймдугаар сард тэр Бүгд найрамдах улсыг татан буулгаж, герман хүн амыг нь Гитлерийн хамсаатан болж болзошгүй хэмээн Сибирь, Казахстан руу цөлсөн юм. Гэхдээ хот тосгоны нэр хэвээр үлдсэн ажээ.

Германуудын даацтай барьсан тохилог, цэлгэр олон байшинд нүүн шилжиж ирсэн украин хамтралчид орсон боловч тэд тав тухтай байж чадсангүй.

– Герман хэдийнэ Сталинградад ирчихээд байна, наашаа ирвэл бидэнд юу гэх вэ?! гэж Варяд байрных нь эзэгтэй санаа алдан үглэнэ. – Германы эд хөрөнгөнд эзэн суучихаад, хүний зовлонгоор жаргал хийж байна уу гээд биднийг хуу дүүжлэнэ. Гэтэл бидний буруу гэж юу байна? Хамтралын малыг туугаад яв гэж тушаасан, бид туугаад явсан, тэгсэн чинь энд оруулчихсан, одоо бид хаачих болж байна, хэн биднийг авах юм?

Варя түүнийг Гитлер ийшээ ирэхгүй гэж тайвшруулахын хамт, айлын шинэ эздийг хэдий өрөвдөвч, эндээс цөлөгдсөн германуудыг бүр ч илүү өрөвдөнө. Өвгөд, авгай, хүүхдүүд юугаараа буруутай юм бэ? Мал зөөврийн вагонд чихэж оруулж түгжээд, хөвч тайгын дунд, юу ч үгүй газар буулгаад хаячихсан. Тэнд хэд нь үхэх бол, хэд нь замдаа үхсэн бол?

Варягийн дарга Давид Абрамович Телянер бас германуудыг өрөвдөж ярина:

– Тэд бол хууль дүрэм ёсчлон сахьдаг оросын харьяат нар, Ижил мөрний цаад биений нутгийг сайхан эзэмшсэн. Тэднээс өмнө тэр талаар зөвхөн ногайчууд, хасгууд л хэсүүчлэн нутагладаг байсан, тэгвэл германууд Ижил мөрний алдарт улаан буудай тариалдаг, тэр буудайн гурилаар эзэн хааны зоогийн ширээний талхыг барьдаг, тамхи тарьдаг, нарийн бөс даавуу нэхдэг байлаа. Тэгсэн хэрнээ харийн хүмүүс гэгдэнэ, уг нь бараг хоёр зууны турш энд аж төрсөн улс, дайны дараа боломж гарах юм бол бүгдээрээ Герман руу яваад өгнө дөө.

тэрээр германуудын тухай ийн ярьж байснаа еврей нарын тухай яриад эхэлнэ.

– Еврейчүүд ч бас ирмэл улс, нэмэрт нь оролцохгүй юм гэж байхгүй. Тэдний дотор улс төрчид, эрдэмтэд, зохиолчид, философичид, зураачид гээд хэн л бол хэн байгаа. Ийм байдалд хэн дуртай байх вэ? Тэгээд л үндсэн ястан нь тэднийг өөрөөсөө хатиг шиг шахаж байгаа юм.

– Лав л манайд тийм биш хэмээн Варя зөрнө. – Манайд еврей олон сонин, театрууд байгаа. Дунд, дээд сургуулийн алинд ч бид еврейчүүд, еврей бусчууд гэж хуваагдаж байгаагүй.

Давид Абрамович хуруугаа гозойлгон,

– Варенька, энэ чинь өөр хүмүүсийн үед, үзэл санааны хүмүүсийн үед тийм байсан юм.

Одоо тэд нар байхгүй. Цаг үе ч өөр болсон. Еврейчүүд олон зууны турш Германд аж төрж ирсэн, герман овогтой хүртэл байсан, идиш хэл бол чухамдаа герман хэл. Гэтэл эцсийн дүндээ? Герман тэднийг устгаж байна. Гэхдээ ард түмнийг устгах боломжгүй. Еврейчүүд хоёр мянган жил өөрсдийгөө хадгалж яваа үндэстэн, түүхийн оноолтоор энэ ард түмэн байж л байх ёстой. Гэхдээ өөрийнхөө оронд байх ёстой. Бусдын ажлыг хөөцөлдөж одоо бол оо.

– Та Палестиныг хэлж байна уу? Еврей нар тийшээ явах юм уу?

– Ийм явдал болсны дараа бол явж л таарна.

– Та ч бас явах уу?

– Хичээх л болно.

– Танай авгай чинь орос шүү дээ.

– Гэхдээ хүүхдүүд нь еврей.

– Тэн хагас хувиар.

– Хүмүүс заримдаа еврей гэдгээ нуудаг. Эх орос, би өөрөө загалмайтай, өөр юу юу ч билээ элдэв юм хэлнэ... Миний хувьд бол Гитлер еврей гэж тонилгож байгаа еврей л еврей. Миний хүүхдүүдийг тонилгох л байсан. Гитлер славянчуудыг ч устгах байсан, тэр чинь дэлхийн бөмбөрцгийн хүн амын талыг тонилгох байсан. Аз болоход дайнд тэр ялахгүй.

– Та тэгж итгэж байна уу?

– Мэдээж. Гэхдээ бидний замбараагүйгээс болж ялалт их үнэтэй тусна.

Тэр хоёр ижил бодолтой ч энэ сэдвээр юм яриад байхгүй.

Аравдугаар сард Москвагаас 15-20 километрийн зайд хамгаалалтын гол зурвасыг барих болж, авгай хүүхнүүд голлосон хэдэн зуун мянган москвачууд өгүүлэхүйеэ бэрх нөхцөлд энэ ажлыг нугалжээ. Германы гутал үнэхээр Москвагаар дэвсэлж явах юм гэж үү?! “Бид Москваг өгөхгүй!” гэсэн анхны хэвшмэл лозун Варягийн сэтгэлд аятайхан бууна.

Игорь Владимирович зураг төслийн газраа тэргүүлэн, урьдын адил цаг баримтлан, шаардлагатай, хичээнгүйлэн ажиллана. түүнд хайш яйш хийсэн зураг авчирч өгч болохгүй. Яль бүл юмыг тоодоггүй Телянер Варяд:

– Та нөхрөө мэднэ шүү дээ, аль болох нямбай хийгээрэй гэнэ.

Игорь Владимирович тухайн үедээ Варяг хамгаалалтын шугам руу очдоггүй ажилд шилжүүлэх гэж оролдсон. Тэгэхэд нь Варя,

– Игорь, би чамаас гуйя, ийм юм хэзээ ч битгий хийгээрэй. Чиний авгай гэдгээр надад ямар ч давуу эрх байхгүй гэж хэлжээ.

түүнээс хойш тэрээр авгайнхаа ажил явдалд оролцохыг больжээ.

Москвагийн тулалдаан амжилттай дууссаны дараа Иогрь Владимировичийг Батлан хамгаалах ардын комиссариатад, Инженерийн цэргийн ерөнхий газарт шилжүүлж, хошууч генерал цол олгожээ. Нөхөр нь шууд дарга нь байхад яршигтай тал байсан болохоор ингэж шилжсэнд нь Варя сэтгэл ханамжтай байв. Варяд ямар нэгэн эрх дарх байхгүй. Гэхдээ эмэгтэй ажилтан нарт тэр болгон цол олгоод байдаггүй атал түүнд нэг их удаагүй байхад нь нэгдүгээр зэргийн цэргийн техникч цол олгожээ. Уул нь дипломтой инженер, энд удаан ажиллаж байгаа энэ тэрийг нь бодвол цол авах нь зүй ёсны хэрэг, гэхдээ л хамт ажиллагсадынх нь дунд “даргын авгай юм чинь” гэх янз байгаа нь мэдэгдээд байсан билээ.

Тийм учраас, удирдах газрыг нь Саратов руу шилжүүлж байгаа, харин чи эндээ, Москвад үлдэнэ гэж Игорь Владимировичийг хэлэхэд Варя тэгж үлдэхээс татгалзжээ.

– Үгүй ээ, Игорь, би удирдах газраасаа гарахгүй.

– Варенька, энд чи яг л тэр ажлаа хийнэ, ганц ялгаа нь гэвэл, энд чи гэртээ байна, тэнд бол бохир модон байшингуудаар хэсүүчлэх ёстой болно.

– Тийм тав тухгүй байдалд хэн хүнгүй өртөнө.

– Варя, тэнд чинь фронт биш, галын шугамаас хол фронтын ар тал. Удирдах газарт чинь бараг бүх хүүхэн нөхөртэйгөө ажиллаж байгаа, чи өмгөөл хамгаалгүй ганцаардана. Ингэхэд, Варюша, чи үнэхээр намайг ганцааранг нь орхих юм гэж үү?

Нөхрөө өрөвдөж байвч явдгаараа л явах болно.

– Миний нөхөр дээгүүр албан тушаалтай учраас би Москвад үлдэх хэрэг үү? Энэ хүмүүстэй би олон жил хамт ажилласан, би ичиж байна. Ер нь ч Москвад сугарч үлдэх хүсэлгүй байна. Би чинь цэргийн дүрэмт хувцастай хүн.

– Би ч гэсэн дүрэмт хувцастай.

– Чи бол Бүх холбоотын хэмжээний дарга, чиний байх газар бол Москва. Би бол жирийн инженер, нэгдүгээр зэргийн цэргийн техникч, миний байх газар бол хүүхнүүд нуувч ухаж байгаа газар.

тэрээр диван дээр зэрэгцэж суугаад, мөрөөр нь тэврэн өөр рүүгээ нааж,

– Варя, би чамайг яах вий гэж айж байна, нэг юм буруу зөрүү хэлчихвэл түүнээс чинь өлгөөд авна, тэнд чинь олон таван юм яриад байхгүй, шууд цэргийн шүүх. Би чамайг явуулахгүй.

– Хэнтэй ч, юу ч ярихгүй байхаа чамд амлая.

тэрээр өвдөг сөхрөн, эхнэрийнхээ хөлийг тэврэн толгойгоо наав.

– Варюша, би чамд мөргөж гуйя, чамайг алдчихна гэж би айж байна.

Нөхөр нь ийн цөхөрч буйд Варя сэтгэл уяран, толгойг нь илэв.

– За, алив бос!

Цаадах нь босохдоо санаандгүй өвдөгнийхөө тоосыг гүвэв...

Варя нүдээ анив. Ээ Бурхан минь! Ийм мөчид өмдөө бодож байдаг байна шүү.

– Үгүй ээ, Игорь, би энд чинь хэн болж таарах вэ? Генералын хангамж эдэлдэг, генералын авгай юу? Би өөртөө ингэхийг яаж зөвшөөрөх сөн билээ. Намайг битгий албад. Би тэнд хянуур болгоомжтой, биеэ барьж явах ам өчгөө өгье.

Нөхөр нь арга буюу хүлцэв. Тэгээд Варя удридах газартайгаа Байдек руу явж оджээ.

Байдек фронтоос хол, германы онгоц ч нисч ирдэггүй газар аж. Варя Телянерийн шууд удирдлаганд ажиллаж, хамгаалах байгууламжийн төлөвлөгөө зохионо. Тэдгээрийг нь хээрийн анги, отрядууд барина, Сталинградад ойрхоныг нь Сталинградын фронтын инженерийн цэрэг барина. Варя Москвагийн хаяанд явж байсан шигээ энд фронтын зааг руу очихгүй.

Ар талын, чухамдаа хагас иргэний байгууллага, гэхдээ хангамж, орон байр, хувцас энэ тэр нарийн заагтай: ахлах, дунд, бага тушаалын командын бүрэлдэхүүн, гэрээт албаныхан, жирийн цэргүүд гэхчилэн. Цол хараахан аваагүй тэргүүлэх инженер улс төрийн хэлтсийн нэг ажилгүй юмнаас доор нөхцөлд байж таарна.

Үүнээс болж зөрчил үүснэ. Игорь Владимировичийн оронд удирдах газрын дарга болсон Бредихин гэдэг ичих нүүргүй, өвчний хөрөнгө хурандаад цөмөөрөө гомдол мэдүүлцгээнэ. Бредихин доод тушаалтантайгаа харилцахдаа ихэмсэглэн ярвалзаж, товчил, бушуул гэх маягтай тэсч ядан, долоовор хуруугаараа ширээ тогшлоно.

Гагцхүү Варятай нэг зиндааных мэт харьцаж, тал олж авахыг хичээн, элдвээр санаа тавьж, захиргаа-аж ахуйн хэлтсийн даргад хүртэл түүнийг харж хандаж бай гэж тушаажээ. түүний тэнэг наргиаг Варя тоомжиргүй сонсоно, ер нь Бердихиний анхаарал халамж, хэлбэрдсэн “өөриймсөг” зан энэ тэр нь доромжлол мэт санагдан, түүнд үнэн голоос дургүй нь хүрнэ. Гэтэл цаад годил нь энэ байдлыг огт анзаарахгүй.

Нэг удаа тэдний хэлтэст зарлага цэрэг амьсгаадан гүйж ирээд,

– Нөхөр нэгдүгээр зэргийн цэргийн техникч, таныг хурандаа дуудаж байна гэжээ.

Бердихин өрөөндөө цугларсан хээрийн ангийн хөлс шороо болсон цэрэг цамцтай, бэржээхэн түрийтгэй, ядарсан инженерүүдийг хямсайж ярвалзан сонсож байна. Варяг хүлээзнэ гэх янзтай сандал руу дохив...

Телянерийг биш яагаад өөрийг нь дуудсан юм бол гэж Варя суух зуур гайхсхийв.

Утас дуугарахад Бердихин авч, сэргэлэн дуугаар,

– Тийм байна... Яг тийм... Байна... гээд утсаа Варяд өгөв.

Москвагаас Игорь залгасан юм байна.

– Варенька, сайн уу, би байна, таньж байна уу?

– Танилгүй яахав... Ямар нэг юм болоо юу?

– Үгүй ээ, зүгээр л чиний дууг сонсмоор санагдаад. Чи яаж шуу байна?

– Би бие сайн, ажлаа хийж байна, чи?

– Би бас бие сайн, ажлаа хийж байна, санаж байна.

– Тэгвэл манай бүх юм дажгүй шив дээ...

– Намайг утасдлаа гэж баярлахгүй байна уу?

– Би энд ганцаараа биш байна, Игорь, за юу? Захиа бичээрэй, тэр нь дээр.

– За тэгье, охин минь, үнсье.

– Үнсье.

тэрээр утсыг нь тавиад,

– Баярлалаа, нөхөр хурандаа гэв.

– Тус болсондоо баяртай байна, нөхөр нэгдүгээр зэргийн цэргийн техникч гэж Бердихин нялганан марзаганах маягтай хариулав.

Бердихин хээрийн ангийн инженерүүдтэй бүдүүлэг харьцаж байгаа хэрнээ өөртэй нь тэгж нялгасанд Варя тэднээс ичиж орхив. Өөртэй нь Москвагаас албаны утсаар ярьж байхад эд нар гэрээсээ хэдэн сараар захиа хүлээж байгаа.

Игорь... Шалан дээрээс босоод өмдөө гүвсэн тэр нэг ердөө эр хүний гэм халгүй хөдөлгөөн түүний гэдэнг яагаад тэгтлээ хөдөлгөсөн юм бол. Аль хэзээнээс дотроо дарж яваа эгдүү нь үнэхээр тэгж буцалж гарлаа гэж үү? Үнэнч, шудрага, журамтай, өөрийг нь аварсан сайн хүн, байн байн захиа бичнэ. Өөрөө бол алдаг оног хариулна, энхрийлэх аргадах үг олдохгүй, өгүүлбэр болгон дээр зовно. Москваг бодохоороо Горькийн гудамжны байраа хэзээ ч дурсахгүй. Арбатаа л санана, өөрийнхөө байшинг, өөрийнхөө өрөөг санана, Сашад илгээмж явуулж байсан Плотниковын хөндлөн гудамжны шууданг санана, тэр илгээмжээ яаж Софья Александровнатай эмхэлж байснаа санана, Сашатай бүжиглэж байсан “Арбатын нүх”-ийг санана... Хэрэв Игорийн тухай бодвол, яагаад ч юм, нөгөө нэг үйлдвэрчний хурал юм уу, Клаваг сэргийлэхэд өгнө гэж муухай дуугаар сүрдүүлж байсан ресторан “Канатик” л улиглан санаанд орно. Тэнгэр минь, энэ бүхэн аль хэзээ улирч өнгөрсөн, тэр дивангарын юмыг ухаж төнхөж байхын хэрэг юу сан билээ? Хамаг учир өөрт нь л байна, түүнд хайргүй, хайртай ч байгаагүй, тэгээд түүнтэй сууснаараа өөрийгөө хуурсан, тэгэхээр түүнийг бас хуурсан хэрэг. Гагцхүү өөрөө л буруутай. Хэрүүл уруулгүй сайхан аж төрж байсан, тэгсэн хэрнээ Игорийг ийш нь ирүүлэх дургүй, өөрөө бол Москва руу хэзээ ч шилжихгүй. Дайны дараа ч Игорь дээр буцаж очихгүй байх... Сэтгэлгүй хүнтэй амьдарч болохгүй, шудрага биш! Игорь дөч хүрээгүй, сайхан хүн, алдартай хүн, амьдралаа төвхнүүлчихнэ. Харин өөрөө бол? Хоёр дахь хүнтэйгээ суусан, дахиад бүтэлгүйтлээ. Ерөөсөө хүнтэй суух хэрэггүй байх.

Варя Ирина Федосеевна гэдэг намын гишүүн, цэргийн эмч хүүхэнтэй нэг өрөөнд амьдарч байгаа. Нэрэлхэх цэрвэх зангүй, эрсхэн хэрнээ ахуй амьдрал дээр бол хүний үгээр тэр авгай хүүхний хов живнээс холуур явдаг нь Варяд аятайхан санагдана. Бас дарга нарын өмнө бөгцөгнөөд байхгүй, өвчтөн нартаа цол, зиндаа харгалзахгүй адилхан санаа тавина, хүмүүсээ

чанд удирдана, сувилагч нарт:

– Охид минь, амрагийн явдлыг толгойноосоо хаяна шүү! Дайны үеийн нөхөр бол түр зуурынх. Варвара Сергеевнагаас жишээ ав, нэг ч эр хүн түүнд хавьтаж чадахгүй гэж сургамжлана.

– Варвара Сергеевнагийн нөхөр Москвад байгаа гэж сувилагч охид зөрөх гэж үзнэ.

– Нөхөр, нөхөр гэнэ, нөхөр нь бялуурчихсан гэж Ирина Федосеевна уцаарлана. – Би өөрийнхөө муу бугийг хөөж явуулсан, хүүхдийн тэтгэмж ч тоож нэхээгүй, хүүгээ өөрөө өсгөсөн, хэдийнэ над шиг эмч болчихсон яваа.

Гучин зургаан онд Изабелла гэдэг испани охиныг авч хүмүүжүүлснээ Варяд ярьсан, охины эцэг эх Мадридыг бөмбөгдөх үед амь алдсан юм байж.

– Сайн охин, арван тав хүрсэн, ухаантай, ажилсаг, багш нар нь ам мэдэн магтана. Тэгж би пролетарийн эв санааны үүргээ биелүүлсэн юм.

Үүнийгээ их бахархалтай хэлсэн, ямар ариун үг юм бэ! Гитлерийг ялна гэдэгт ямар ч эргэлзээгүй итгэнэ, түүний баталгаа нь манай нийгмийн байгуулал – зөвлөлт засаг гэнэ.

– Зөвлөлт засаг байгаагүй бол бид хэн байх байсан бэ? Миний эцэг зүгээр хөдөөний хар хүн, ээж бичиг үсэггүй хөдөөний авгай, гэтэл би дээд боловсролтой. Надад үүнийг хэн өгөв? Зөвлөлт засаг. Манай удирдах газрын инженер, техникчид хаанаас гараав? Ард түмний дундаас. Генерал, жанжнууд нь Улаан Армийн жирийн дайчдаас төрсөн, бүгд яс махнаасаа ард түмнийх, ямар ч Гитлер манийг гэтлэхгүй.

Есдүгээр сард Удирдах газрыг шинээр байгуулсан Донын фронтын мэдэлд шилжүүлж, Сталинградын замд буй нэг тосгонд байрлуулжээ. Тэднийг зориуд ирүүлсэн авто суман нүүлгэжээ. Варя Сашаг цэргийн жолооч хийж байгаа гэж Нинагаас дуулсан болохоор энд явж байх юм биш биз гэж жолооч нарын царайг ажиглана. Саша байсангүй, юу гэж ч хүн үнэмшимгүй тэгж таарч байх вэ дээ.

Тэдний байрласан тосгоноос Сталинград хүртэл зуу хүрэхгүй километр, дайн энүүхэнд болж байгаа нь андашгүй. Варя Москва орчмынх шиг фронтын зааг руу үе үе явна. Заримдаа шалган нэвтрүүлэх цэгийн дэргэд замын машин хүлээж хэдэн цаг сууна. Тэгж байхдаа жолооны ард суугаа Сашаг харна гэх утгагүй санаа нь толгойноос салж өгөхгүй, түүгээр өнгөрч байгаа жолооч нарыг сурсан зангаараа ажиглана. Тэнгэрийн хаяанд түймэр улалзан, германы онгоц хавийн зам, Ижил мөрнөөр явж байгаа хөлөг онгоц энэ тэрийг бөмбөгдөнө. Тэдгээр онгоц руу манай сөнөөгч дайрч устгах нь бахтай, агаарын тулалдааныг өдөр өнжихгүй харж болно.

Тэгж тэгж Варяд хэрэгтэй машин ирэхэд, тэрээр ачаа, хүн нь овоорсон тэвш рүү авиран гарна. Нэг удаа Телянерийн хамт Заварькино руу, инженерийн цэргийн штабт очив. Залуухан, ажил хэрэгч цэргийн инженерүүд бүх асуудлыг шуурхай, зоригтой шийднэ. Сайхан зантай тэдгээр залуус Телянерт соруул, Варяд бариулыг нь герман цахилгааны утсаар

ороосон кинжал бэлэглэжээ.

– Гоё л юм, гэхдээ би кинжалаар яах билээ? гэж Варя асуув.

– Энэ чинь эмэгтэй хүний кинжал, харж байгаа биз дээ, ийм жижигхэн гэж бэлэглэсэн инженер нь тайлбарлав.

– Өөрийгөө хамгаалахгүй юү гээд хоёр дахь нь инээмсэглэв.

– Гардан байлдаанд гэж гурав дахь нь нүд ирмэв.

Сайхан сэтгэлтэй, энгийн, хөгжилтэй залуус.

Нэг удаа хамгаалалтын ар талын төлөвлөгөөг зөвшилцөн тохиролцох юм болов. Бэхлэлтийн хэлтсийн дарга Свинкин гэж Телянерээс тохой өндөр залуу хурандаа сэтгэл тун хангалуун байв.

– Одоо генералаар батлуулчихъя.

– Гэхдээ эхлээд манай удирдлага гарын үсэг зурах ёстой хэмээн Телянер эргэлзэв.

– Нөхөр хошууч, таныг буцааж аваачиж гарын үсэг зуруултал, тэгээд нааш нь ирүүлтэл, дараа нь би генерал руу оруултал мөн ч их хугацаа өнгөрнө, гэтэл тийм хугацаа алга, тэр зурвас бэхлэлтийг яаралтай барих хэрэгтэй. Та нар тэндээ саналаа нэгтгэсэн юм байгаа биз дээ? гэж Свинкин зөрөв.

– Тэгэлгүй яахав, ерөнхий инженертэйгээ ярилцаж тохиролцсон.

– За тэр дээ, явцгаая!

Тэд фронтын инженерийн цэргийн дарга, эелдэг тогтуун, дөчин настай генерал Алексей Иванович Прошляков дээр орохоор явцгаав. Төлөвлөгөөгөө илтгэлээ, Прошляков анхааралтай сонслоо, зургийг нь нягтлан ажиглалаа, илүү дутуу юм асуусангүй, дээр нь: “Батлав” гээд биччихлээ, Варя руу зэрвэхэн мэт харц шидлээ. Варя тийм харцанд дасчихсан учраас илэрхий хэнэггүй царайлав.

Свинкин салахын үед,

– Та нар тэр удирдах газраа зэврэх нь, манайд шилжээд ир. Давид Абрамович жилийн дараа хурандаа, Варвара Сергеевна хошууч болно. Би нээрэнхээсээ ярьж байна шүү гэв.

Удирдах газраа буцаж ирлээ. Телянер Бредихинд илтгэхээр явав. Царай дарсан, ууртай амьтан буцаж ирээд, зурагнуудаа ширээн дээр хаяв.

– Юу болоов? гэж Варя асуув.

– Манай модон толгойт өөрийнх нь зөвшөөрөлгүй Прошляковт хандлаа гэж ярдаглаж байна.

– Бид хандаагүй, биднийг түүн рүү аваачсан шүү дээ.

– Би зөндөөн тайлбарласан, юу ч сонсохыг хүсэхгүй байна.

– Заяагүй дүйрэн!

– Тэр чинь дүйрэн биш, өөрөө л генерал дээр орох санаатай байсан юм байна.

Төдөлгүй зарлага цэрэг гүйж ирэв.

– Нөхөр нэгдүгээр зэргийн цэргийн техникч, хурандаа таныг дуудаж байна!

– За та оч, гэрч гэдгээр таныг байцаана гэж Телянер өгүүлэв.

Варя Бредихин дээр ороход цаадах нь сандал руу дохив.

– Фронтын штабт та нар чинь яасан улс вэ?

– Яагаа ч үгүй. Төлөвлөгөө л баталж өглөө.

– Генерал Прошляков дээр орсон уу?

– Тэгсэн.

– Варвара Сергеевна, би таныг буруушаахгүй байна. Харин Телянер, удирдах газартай тохиролцохгүй яаж тэгж чадаж байна?

– Төлөвлөгөөг ерөнхий инженертэй ярьж тохиролцсон.

– Төлөвлөгөөн дээр ерөнхий инженерийн гарын үсэг алга, минийх ч байхгүй. Тэр чинь яаж бидний толгой дээгүүр харайж байна?

– Хошууч Телянер генерал руу очих дургүй байсан. Гэтэл хурандаа Свинкин төлөвлөгөөг шууд маргааш цэргийн байрлал руу явуулахын тулд нэн даруй батлуул гэж шаардсан. Тэгээд өөрөө төлөвлөгөөг аваад генерал руу явахдаа биднийг дагуулж явсан.

– Та... Та бол энд хамаагүй. Гэтэл Телянер... Телянер... Генерал руу очихгүй гэх ёстой байсан. Гэтэл чинь үгүй шүү, өөрийгөө л харуулах гэж тэр шүү дээ.

тэрээр толгой сэгсэрч, муухай хямсалзав:

– Ийм л үндэстэн! Нүх сүв болгоноор шургална! Тослохгүй зүтгэлнэ.

Варя босов.

– Та “үндэстэн” гэв үү?! Та еврейг адлагч үзэлтэн үү? Нацист уу? Фашист уу? Та яаж ингэж чадаж байна аа?!

Бредихин бас босов.

– Хөөе, хөөе, та энд жаахан аядаарай! Генералын авгай гэхээр яасан ч болно гэж бодоо юу?!

– Би тантай ярихыг хүсэхгүй байна... Би таныг сонсохыг хүсэхгүй байна!..

– Сонсох л болно доо! Хүмүүсийн хооронд яс хаяхыг зөвшөөрөхгүй! гэж Бредихин муухай зандрав.

– За тэгвэл, хурандаа, та одоо боловсон хүчний хэлтсийн даргыг дуудаж, надад фронтын инженерийн цэргийн штабт шилжих бичиг хийлгэж аль. Маргааш өглөө тийшээ очих машин гаргаж аль. Та илүү дэлүү хэрүүл шуугиан хүсэхгүй байгаа бол ийм дээрээ салцгаая.

Маргааш нь Варяд түүнийг фронтын инженерийн цэргийн штабын мэдэлд шилжүүлж байгаа тухай бичиг, битүүмжилсэн хувийн хэргийнх нь хамт гардуулав. тэрээр хурандаагийн машиныг хөлөглөн Заварькино руу одов.

Долоо хоногийн дараа Телянер ч бас фронтын инженерийн цэргийн штаб руу шилжжээ.

Сталинградад хүнд тулалдаан болж байв. Германууд хотын дээрээс мянга мянган дэлбэлэх болон шатаах бөмбөг хаялана. Байшин барилга хөрөөдсөн аврага том мод шиг хажуу тийш бөөрлөн унана. Гал авалцсан, утаа бүрхсэн, үнс пүргэсэн хот нуранги болон хөглөрч, зөвлөлтийн цэрэг тэнд тоосго болгоны төлөө тулалдаж байв.

Наймдугаар сарын 29-нд Жуков Камышинд нисч ирж, тэндээс машинаар урагш явж, дараа нь баруун зүгт эргэв. Сталинградын фронтын ангиуд Ижил, Донын завсрын богинохон зайд (60 километр) байрлаж байсан бөгөөд тэдгээрийн эсрэг Сталинградтай харилцах холбоог хамгаалж байгаа германы явган цэргийн дивизүүд нүүрлэжээ.

Наймдугаар сарын наранд хуйхлагдсан Ижил орчмын тал, дайсны их бууны галд ив илхэн гуу, жалганууд. Жуков энд байрласан армийн штабаар орж, генерал Малиновский, Казаков хоёртой уулзахад тэд ижил бодолтой байв: ийм газраар довтлох боломж байхгүй. Эндээс Сталинград руу нэвтрэх боломжгүйг Жуков өөрөө ч харлаа. Цааш баруун тийшилж, Клетская, Серафимович руу явлаа. Энд цэргийг Донын баруун эрэг дээр барьж байгаа, тэдний эсрэг румынууд зогсож байгаа юм.

Орловский гацаанд түүнийг Хорин нэгдүгээр армийн командлагч өөрийн бодолтой, нарийн мэрэгжлийн генерал Данилов тосч уулзаад байдлыг илтгэв. Хорин нэгдүгээр армийн дивизүүд Донын баруун эргийг найдвартай барьж байгаа аж. Румынууд дайрах гэж оролдсон боловч үлбэгэр довтолж, одоо идэвхигүй байгаа гэнэ. Германууд Сталинградад амжилт олвол, мэдээж, хойд зүгт ерөнхий довтолгоо эхэлж, румынууд германы сайн зэвсэглэсэн, туршлагатай ангиудаар хүч сэлбэнэ. Хамгаалалтаа бэхжүүлэх хэрэгтэй. Данилов бусдын адил хамгаалалтад байх бодолтой аж. Жуков ч зөрсөнгүй. Гэхдээ өөр юмны тухай бодож байж: түүний толгойд боловсорч байгаа, одоо хэр хараахан хүнтэй санал бодлоо солилцоогүй байгаа төлөвлөгөөний нэг оролцогч нь чухамхүү Хорин нэгдүгээр арми болох ёстой.

Маргааш нь Жуков, Данилов хоёр цэргийн байрлал руу явцгаав. Бас л гуу жалгаар хэрчигдсэн задгай газар, гэхдээ нэлээд өндөрлөг газар. Дайсныг ажиглахад дажгүй хараатай, хөдөлж байлдах нөхцөл сайн, бут сөөгтэй, нуугдаж болно. Мэдээж, зам нь хариу байхгүй. Гэхдээ арван нэгдүгээр сард жаварлана, эндхийн хөрс хатуу, техник явахнаа явчихна.

Орой гэхэд гацаанд буцаж ирцгээв. Оройн хоолны үеэр Данилов дивиз, хороо, бригад командлагчдын тухай илтгэв. Жуков заримыг нь мэдэх, заримыг мэдэхгүй боловч Даниловт итгэж байв. Данилов Ефимов, Костин гэдэг хоёр дивизийн даргын хурандаа цолыг ахиулж өгөхийг хүсэв.

– Ефимов бол ахмад цэрэг, түүнд генерал өгөх цаг болсон гэж Жуков өгүүлээд, – Костиныг би бүр Алс Дорнодод байхад нь анзаарсан, ирээдүйтэй залуу, нэмэрт нь Зөвлөлт Холбоот Улсын баатар. Гэхдээ даанч залуу, ердөө гучтай, арай ахмад хүмүүс бий шүү гэв.

– Тэр энэ цолыг авах гавьяатай, би бас түүний байр суурийг бэхжүүлмээр байгаа юм.

– Ингэх зайлшгүй шаардлага байна уу?

– Та өөрөө нас залуу гэж хэллээ шүү дээ!

Жуков Костиныг зөвхөн Алс Дорнодоор ч мэдэж байгаа юм биш. Максимын эцэг эх нь Калуга мужийн Жуковын төрсөн Стрелково тосгоных. Жуковыг Москвад элдүүрчин хийж сурч байхад эцэг нь хүүгээ эргэж ирэхдээ Арбатад, Костиныхныд буудаг байсан юм. Костин тэнд галч хийдэг, түүний авгай, Максимын эх цахилгаан шатны жижүүр байсан юм. Жуков ч өөрөө хүүхэд байхдаа тэднийхээр орж гардаг байсан бол хориод онд Улаан Армийн дарга болчихсон, тэднийд буусан ээжтэйгээ уулзахаар очиж байсан удаатай. Алс Дорнодод удирдах бүрэлдэхүүний нэрсийн жагсаалтад дэслэгч Максим Иванович Костин гэсэн нэр байхыг үзээд, нөгөө гэр бүлийнх биш биз гэж бодоод, дуудуулж ярилцтал мөн болж таарчээ. Тэгэхэд Костин түүнд аятайхан сэтгэгдэл төрүүлсэн. Сайн ч байлдаж асан. Хэрэв Данилов түүний байр суурийг бэхжүүлэх ёстой гэж үзэж байгаа бол тэгэх ямар нэг учир шалтгаан байх нь.

– Та ажлаа хий, харин Костиныг над руу дуудуул гэж Жуков хэлэв.

– түүнийг олтол, тэгээд иртэл цаг явчихна.

– Зүгээр, би гурав-дөрвөн цаг ажиллана.

Максим армийн штабт ирэх дуудлага авмагц тэр даруй замд гарав. Жуков энд байгаа гэдэг чинь бусад дивизийн дарга нар ч дуудагдсан хэрэг, зөвөлгөөн хийх нь, заавар, банга өгөх нь. Жуковыг харвал сонин байна, түүнийг дайнаас өмнө, Алс Дорнодод ганцхан удаа харсан, нэг нутгийнхан болж таарсан. Жуков өөрийг нь санах юу л бол, харин Максим бол түүгээр бахархаж яваа: улс орны нэгдүгээр жанжин, нэр алдар нь дэлхий даяар цууриатаж байна, гэтэл манай тосгоных шүү дээ.

Ноднин Москвад байхад нь ээж нь Жуковынхны тухай ярьж өгсөн.

– түүний эцгийг, хаягдмал Константиныг, нэг ганц бие авгай хүүхэд асрах газраас авсан юм. Найм хүрэхээр нь Угодскийн үйлдвэрийн гуталчинд дагалдан болгож өгсөн, дараа нь Москвад гуталчин хийсэн, тэгээд буцаж тосгондоо очсон, бэлэвсэрсэн, бүр тавь хүрсэн хойноо дахиж гэрлэсэн, тэр нь хөрш “Черная грязь” тосгоны бас бэлэвсэн хүүхэн. Устинья Артемьевна гэдэг юм, нэг их залуу биш, гучин тавтай. Товчдоо, хоёулаа бэлэвсэн, хоёулаа хоёр дахиа гэрлэсэн нь тэр. Тэгээд тэднийд Георгий хүү нь төрсөн, бас нэг хүү гарсан нь нялхаараа бүтээгүй юм. Ядмаг аж төрж байсан, ер нь манай тосгонд баян айл байхгүй, газар ховор, үржил шим муутай, газар шороотой хэн ноцолдоно гээч? Өвгөд, авгай, хүүхнүүд л ноцолдоно, эрчүүд нь гэвэл, тэд нар нь Москва, Питер рүү ажил хөөгөөд явчихна. Устинья Артемьевна бол онцгой хүүхэн, таван пудын шуудайтай тариаг ажрахгүй зөөнө, баргийн эр хүн даахгүй юмыг. Малоярославецаас ачаа зөөнө, бас л эр хүний ажил, зантай хүүхэн, Георгий эхийгээ дуурайсан юм, зүс төрх нь ч адилхан.

Ээж нь түүнд ингэж ярьсан. Бас, энэ жил Устинья Артемьевнаг харсан, тэдний тосгоныг германууд эзлэхийн өмнөхөн Жуков эхийгээ аваад явсан гэж хэлсэн.

Максим энэ бүхнийг армийн штабт очих замдаа дурсан бодож явсан бөгөөд ирсэн хойноо мэдвэл ямар ч зөвөлгөөн энэ тэр байхгүй, Жуков ганцхан түүнийг дуудсан болж таарав.

– Чамтай ойрд уулзсангүй, суу, ажил явдал ямар байна, яриад бай, ар гэрийнхэн чинь сайн уу?

– Ар гэрийнхэн дажгүй. Ээж амьд мэнд, дүү нар армид, авгай сургуульд багшилж байгаа, хүү том болж байна.

– Хүү хэд хүрч байна?

– Бүр тав хүрчихсэн.

– Нэр нь?

– Иван.

Жуков түүнийг бахдан харав: Ханхар цээжтэй, малигар царайтай, нас залуу, ийм дарга нарт цэргүүд дуртай, тариачин гаралтай, манай хүн гэдэг нь андашгүй.

– Танай дивизэд юу болоод байгаа юм, тэрийгээ ярь.

– Манай дивизэд үү? Юу ч болоогүй. Бүх юм номоороо байгаа.

– За, боль хө, үнэнээ хэл. Генералдаа юу гэж илтгэсэн юм?

Максим чимээгүй байзнаснаа,

– Би түүнд юу ч илтгээгүй, нөхөр армийн генерал хэмээн эхлэв. – түүнд миний талаар гомдол мэдүүлсэн байж магадгүй, би улс төрийн орлогчтойгоо гар нийлэхгүй байгаа юм. Ямар л асуудал гарна, дандаа зөрчилдөнө. Сүүлчийнх нь гэхэд л нэг сумангийн даргаас болсон, нэг байлдагчийг нүүр рүү нульсан учраас түүнийг би тушаалаас нь буулгасан юм. Тэгсэн чинь улс төрийн орлогч: “Яагаад надад мэдэгдэхгүй ингэж байгаа юм бэ, тэр сумангийн дарга бол улс төрийн хувьд төлөв, ёс суртахууны хувьд тогтвортой коммунист” гэх мэт баахан юм ярьсан. Тэгээд, мэдээж, армийн улс төрийн хэлтэст илтгээ л дээ.

– Цохьсон нь зүйтэй байсан юм биш биз? Даргыгаа тэгэхээс өөр аргагүй болгосон юм биш биз?

– Улаан Армийн дайчныг зодож болно гэж үү? Хэрэв буруутай бол шүүнэ, тушаал бууруулна. Харин зодох, шоовдорлох, хүний нэр төрийг доромжлох эрх тэрэнд байхгүй.

– Манай бага дарга намайг цэрэг байхад малиагаар яаж гүвшдэг байсан гэж санана, би тэгэхэд морин цэрэгт алба хааж байсан юм.

– Тэр чинь хааны арми, нөхөр генерал...

– Бас элдүүрчний дагалдан хийж байхад эзэн яаж нулина гээч.

Максим аль болохоор аядуу ярихыг хичээж байв:

– Гар хүрэх явдал манай дивизэд гарахыг би хэзээ ч зөвшөөрөхгүй. Румыныхан л цэргээ зодож жанчдаг учраас цаадуул нь тэгж арчаагүй байлдаж байгаа юм, бид бол Улаан Арми, манай армийн байлдагч болгон өөрийгөө хүндэтгэх ёстой, бас дарга нь ч түүнийг хүндэтгэх ёстой.

– Үгүй ер, надад яасан мундаг ном тавьж байх юм! хэмээн Жуков мушилзаж, – Би чинь Улаан Армид байгуулсан цагаас нь байгаа, бас намд арван есөн оноос байгаа хүн шүү дээ. Чи бол хэдэн оноос намд байна?

– Намд гучин дөрвөн оноос, комсомолд хорин таван оноос.

Хорин таван оноос комсомолд... Энэ нь Жуковт нэг юм сануулах шиг... Өө тийм, нөгөө Старожиловод байсан жолоочийг...

– Та нар мөн шартай шүү! Ноднин надтай бас нэг тийм нөхөр таарсан юм, чиний л насных байх. Байлдагч жолооч. Бас өөрийнхөөрөө зүтгээд байсан. Би түүнийг буудан алах гэж байснаа болиод цол олгосон. Бас инженер байсан гээд бодчих.

Байлдагч жолооч, инженер, өөрийнх нь чацуутан...

Максим босов.

– Нөхөр армийн генерал, асуулт тавихыг зөвшөөрнө үү?

– Асуу, асуу.

– Та овгийг нь санахгүй биз?

– Овгийг нь үү... Санахгүй байна...

– Панкратов гээгүй биз?

– Өө тийм, Панкратов... Чи яагаад догдолчихов, таньдаг юм уу, хаашаа юм?

– Багын найз, нэг байшинд өссөн, сургуульд нэг ширээн дээр сууж байлаа... Даанч хувь тавилан...

Жуков түүнийг үгийг тасдав:

– Одоо бүгд нэг хувь тавилантай, байлдах л хэрэгтэй байгаа.

– Ойлголоо, нөхөр генерал!

Тийм хувь тавилангийн тухай ярих хүсэлгүй байгаа нь тодорхой байна.

Жуков зураг руу тонгойж, тонгойсон чигээрээ,

– Чиний улс төрийн орлогчийг цаадуул чинь солино. Харин чи шинэтэй нь учраа ололцох юм

уу, үгүй юм уу? Өөрийгөө ч бас мэдэж бай гэв.

Жуков есдүгээр сарын гурванд Сталинаас: “Дайсанд нэн даруй цохилт өг, удаашруулах нь гэмт хэрэгтэй адил” гэж шаардсан цахилгаан авав. Маргааш нь Сталин Маленков руу утасдаж шийдвэр нь хэрхэн биелж байгааг шалгав. Маленков цэргийн явдлын талаар холтлох юм үнэн байхгүй, зүгээр л Жуковын дэргэдэх Сталины шалгагч байсан тул түүний уцаар дууг сонсоод бажга алдав.

– Нөхцөл байдал туйлын хүнд байна, нөхөр Сталин. Германы бөмбөгдөгч онгоцнууд өдөрт хоёр мянга хүртэл нислэг үйлдэж байна. Манай цэрэг хэд хэдэн удаа довтлох гэж үзсэн боловч ямар ч үр дүнд хүрсэнгүй.

Сэтгэл дундуур Сталин Жуков, Васильевский хоёрыг Москва руу дуудав.

– Яагаад довтлохгүй байна?

– Сталинград орчмын газар довтолгоо хийхэд бидэнд ашиггүй, гүнзгий жалгануудад нь дайсан манай галаас сайхан нуугдаж байгаад, өндөрлөгийг эзэлж авахаараа харин ч бидний эсрэг хүчтэй галлах боломжтой болж байна. Өөр шийдэл хайх хэрэгтэй байна гэж Жуков илтгэв.

– Сталинград хавийн газрын байдлыг би танаас доргүй мэднэ. Ямар шийдэл байна?

Поскребышев орж ирэв.

– Нөхөр Сталин, нөхөр Берия утасдаж байна, тантай яаралтай ярья гэнэ.

Сталин утсаа авч Берияг сонсоод, царай нь барайгаад явчихав.

– Хүрээд ир!

Утсаа тавиад Жуков руу муухай харав.

– За тэгвэл өөр ямар шийдэл байна?

– Нөхөр Васильевский бид хоёр тэр тухай сайн бодъё, бидэнд нэг хоног хэрэгтэй.

– За яахав, маргааш орой есд дахиад эндээ цуглая.

Берия яаралтай мэдээтэй орж ирэв. Яков олджээ. Өвөл Берлинд, гестапогийн мэдлийн буудалд байсан аж. Дөчин хоёр оны эхээр Любек рүү “Офлаг ХС” гэдэг офицерийн лагерьт шилжүүлсэн байна. түүний хөрш нь ахмад Рене Блюм, Францын ерөнхий асан Леон Блюмийн хүү...

– Блюмийн гэнэ ээ? Германиуд чинь еврейг офицерийн лагерьт байлгадаг юм уу?

– Тийм. Наймаалцах, панзлах гэж хамгийн алдартайчуудыг нь тэгж байгаа. Биднийг еврей

нарыг устгаж байна гэдэг, тэгвэл энэ еврей Блюм байж л байна, нүдээ хужирлацгаа! гэж төөрөгдүүлэх мэдээ тараана.

– Тийм бий, цааш нь ярь!

– Любект офицерүүд Улаан Загалмайгаар дамжуулан авдаг илгээмжнээс Яковт тавьж өгөхөөр шийдэж.

– Тэрийг нь Яков авч байх уу?!

– Олон улсын Улаан Загалмай нийгэмлэгийн илгээмж гэж Берия давтан хэлэв.

– Биечлэн Гитлерээс биш гэдгийг би өөрөө ойлгож байна. Гэхдээ манай бусад олзлогдсон офицерүүд тийм илгээмж авахгүй байгаа шүү дээ.

– Манай бараг бүх офицер нийтийн лагерьт байгаа, офицериинхт маш цөөхөн. Тэдэнд илгээмж хуваарилдаг эсэхийг би мэдэхгүй. Тодруулъя.

Сталин дуугарсангүй.

– Олзлогдогсдын дунд манай хүмүүс байгаа, миний мэдэж байгаагаар бол оргуулахаар бэлтгэж байгаа.

– Тэр тэгээд хаашаа гүйх болж байна?

– Оргуулах төлөвлөгөөг боловсруулж байгаа гэж Берия цэнэсхийн хариулав.

Яковыг олцгоож. Берлинд буудалд байсныг лагерьт шилжүүлсэн гэдэг бол тэдний талд орохоос татгалзсан гэсэн үг. Тэгсэн ч гэсэн бүх фронтоор “Сталины хүүгээс үлгэр авцгаа!” гэсэн германы ухуулах хуудсаар хөглөрч байна. Яковыг амьд байгаа цагт германууд тийм хуудсыг цацсаар байх болно. Яковыг үхсэн цагт л цацахаа болино. Гагцхүү тэгсэн цагт. Гэвч түүнд энэ тухай бодож байх зав алга. Берия л бодог.

Сталин босов.

– Олноос оргоно гэдэг бол Улаан Армийн даргын хувьд нэр төртэй гарц.

Тэгж хэлээд нөгөө муухай харцаараа Берияг харав.

– Мэдээж, оргох явцад түүнийг алж мэднэ. Тэгсэн байлаа гэхэд, тийм үхэл бол Улаан Армийн даргын хувьд бас нэр төртэй гарц.

Маргааш орой нь есөн цагт Жуков, Васильевский хоёр Сталины өмнө зургаа дэлгэж тавилаа. Жуков илтгэв.

– Паулюсын арми германы үндсэн хүчтэй нарийхан зурвас газраар холбогдож байгаа. Тэр зурвасын хойд талыг румын, унгар, италичууд хамгаалж байгаа. Тэд зэр зэвсэгээр гойдгүй,

байлдааны олигтой туршлага байхгүй. Харилцах замын өмнөд хэсгийг мөн тиймэрхүү чансаатай румыны арми хамгаалж байгаа. Бидний төлөвлөгөө гэвэл? Серафимович, Клетскаягийн дүүрэгт Калачийн хавиар эрчимтэй цохилт өгөх цэргийн маш хүчирхэг бүлэглэлийг бүрдүүлж, тэр бүлэг Сталинградаас өмнүүр цохилт өгөх бүлэгтэй нийлнэ. Паулюсын арми бүслэгдэнэ. Үүнтэй нэгэн зэрэг, германуудад Сталинградад бүслэгдсэн цэргээ гаргах боломж олгохгүйн тулд баруун талаар цохилт өгнө.

Сталин зургийг сүрхий ажиглаж байна.

– Мөн ч холуур далайж байх чинь вэ... Хаа хамаагүй, Доноос баруун тийш. Сталинград руу ойр байх хэрэгтэй, үгүйдээн Донын зүүн эргийн дагуу.

– Тэгэх боломж байхгүй гэж Жуков зөрөв. – Германы танк Сталинградын хаяанаас баруун тийш эргэж манай цохилтыг хаана.

– Манай хүч ийм том ажилбарт хүрэлцэх юм уу?

– Одоо бол хүрэлцэхгүй гэж Васильевский хариулав. – Гэхдээ арван нэгдүгээр сар гэхэд боломжийн хүчээр хангаад, ажилбарыг сайтар бэлтгэж болно.

Сталин харандаагаа ширээн дээр шидлээ.

– Тэгвэл арван нэгдүгээр сар гэхэд чинь германууд Сталинградыг эзэлчихээд, Саратов руу хөдөлнө биз дээ?!

– Паулюсын цэрэг туйлдаж гүйцсэн, хотыг эзэлж авах чадвар байхгүй гэж Жуков хариулав. – Мэдээж, бидний хохирол ч маш их, гэхдээ бид ойрын хэдэн өдөрт хот руу шинэ сэлбэг хүч хаяна, Сталинградыг алдахгүй хамгаална.

Тэгтэл бас өчигдөрийнх шиг Поскребышев орж ирээд, Сталинградаас Еременко утасдаж байна гэж илтгэв.

Сталин утсаа авч, ярьсныг нь сонсоод, “Мэдлээ” гэж ганц үг хэлээд, Жуков руу харснаа Васильевскийг харж, тэгснээ дахиад Жуков руу харав.

– Та нар: “Дайсан туйлдаж гүйцсэн” гэж ярьж байна. Тэгвэл Еременко: германууд хот руу танкийн ангиудаа дөхүүлж байна, маргааш шинэ цохилт ирнэ гэж үзвэл зохино гэж илтгэж байна. Та хоёр яг одоо Сталинград руу нис, хотыг ямар ч үнэ цэнээр хамаагүй, ямар ч байлаа гэсэн хамгаал.

Васильевский зургаа хуйлж аваад,

– Бидний төлөвлөгөөг яах вэ? гэж цэрвэсхийн асуув.

– Бид наадахыг чинь эргэж ярина, цаг олдоно, онгоцны буудал руу явцгаа. Цагийн дараа гэхэд та нар нисчихсэн байх ёстой гэж Сталин бачимдав.

Сталинградын балгас дээр ширүүн тулалдаан үргэлжилсээр. Гэхдээ германууд урагш ахиж чадсангүй. Зөвлөлтийн цэрэг урьдын адил айхтар шаргуу хамгаалан байлдаж байв.

Жуков тэр хооронд Серафимович, Клетская хавийн байдлыг судлан, армийн командлагч нартай сөрөг довтолгооныхоо төлөвлөгөөг нарийсган тодотгож байлаа. Васильевский зүүн жигүүрт мөн тийм ажил хийж байв. Сталин заримдаа тэднийг Москва руу дуудан ирүүлж, төлөвлөгөөний нарийн ширийн рүү орох тусам лут том санаа сэдсэнийг ухамсарлаж эхэлсэн байна. Иргэний дайны үед тэрээр Царицынд нэг бус сарыг өнгөрөөсөн, хамгаалалтыг удирдаж, Москва, Петроград руу үр тариатай галт тэрэгний цуваа явуулж асан. Чухам тийм учраас Царицыны нэрийг сольж, түүнд зориулан Сталинград гэж нэрлэсэн. Тэгэхэд Надя ч хамт байсан. Тэнд салхинд цохиулсан, түүнээс хойш дагуулж хол явахаа больсон. Залуухан, томоогүй амьтан байж дээ, “Волга руу оч, сонсдон бүхий гаслан хэнийх вэ...” гээд л Некрасовыг дурсаад байх, Тэгээд тэнд, тэр Волгийнхоо эрэг дээр салхинд цохиулчихсан...

Сталин зураг дээрх Калачийн хойно, өмнөөс татсан улаан сумыг тогтон харав. тэрээр ажилбар амжилттай болно гэж итгэчихээд сурсан зангаараа бүх хүнийг яаруулж эхлэв. Шинэ шинэ фронт, арми байгуулж, буучдын дивиз, танкийн бригадуудыг шилжүүлэн байршуулж, агаарын цэргийн армийн хүчийг бэхжүүлж олон зүйл бэлтгэл хийв. Тэг тэгсээр төлөвлөгөөний эцсийн хувилбарт Жуков, Васильевский хоёр гарын үсэг зурж, дээр нь Сталин: “Батлав” хэмээн мутарлав.

– Нөхөр Сталин! хэмээн тэр даруй Жуков түүнд хандав. – Паулюст дэмжлэг болгохоор германыг цэргээ тийш нь хаяулахгүйн тулд Москва орчимд, Вязьма, Ржевийн хавиар анхаарал сарниулах цохилт нэн даруй хийж эхлэх хэрэгтэй.

– За яахав, бодъё... гээд Сталин Жуков руу харав. – Бодъё... Энэ зөв санаа шиг байна... Бодъё... Харин одоо бол та буцаад нис, довтолгоонд хэр бэлэн байгаагаа шалга.

Жуков арван нэгдүгээр сарын 16-нд утасдаж бүх юм бэлэн болсныг илтгэж, 19-ний өглөө довтолгоог эхлэнэ гэж мэдэгдэв.

Жуков дахиад Москвад нисч ирлээ. түүний илтгэл итгэлтэй, найдвар төгс байв: бүх арми довтлоход бэлэн болсон, ажилбар амжилттай болоход эргэлзэх юм байхгүй.

– За тийм байж, сайн байна гэж Сталин хэлэв. – Маш сайн байна. Баяр хүргэе. Ажилбарыг амжилттай болсон цагт дахин баяр хүргэнэ.

– Баярлалаа, нөхөр Сталин!

Сталин түүн рүү ширтэн харав...

– Нөхөр Жуков! Та өнгөрсөн удаа Вязьма, Ржевийн хавиар анхаарал сарниулах цохилт хийх тухай ярьж байсан.

– Тийм, энэ зайлшгүй чухал.

Сталин босч хажуугийн ширээн дээрээс зураг авчирч Жуковын өмнө тавив.

– За энэ, Жанжин штабынхны боловсруулсан төлөвлөгөө, та харна уу.

Жуковыг зурагтай танилцах хооронд Сталин өрөөн дундуураа явзнав. Жуков үзэж дуусаад,

– Санаа нь зүйтэй юм байна, нарийн ширийн юмыг нь гүйцээж тодотгох хэрэгтэй гэв.

– Бид энд бас гар хумхиж суугаагүйг та харж байгаа биз хэмээн Сталин жуумалзав. – Нөхөр Жуков, энэ ажилбарыг хэнд хариуцуулж болохов, та юу гэж бодож байна?

– Шууд нэр хэлэхэд төвөгтэй байна. Нөхөр Васильевский бид хоёр энэ тухай ярилцъя.

Сталин зөөлөн сандалдаа дахин тухлан суугаад Жуков руу харав.

– Энэ ажилбарыг та өөрөө хариуцвал ямар вэ? Сталинградад бүх бэлтгэл хангагдсан. Тэнд нөхөр Васильевский байгаа, фронтуудыг туршлагатай хүмүүс командалж байна: Рокоссовский, Еременко, Ватутин. Тэднийг тийм хүчээр дөнгөнө гэж би бодож байна. Тэгээд ч, бэлэн байдал бүрэн хангагдсан, амжилт эргэлзээгүй гэж та хэлж байгаа юм чинь.

Жуков зөрүү харав. Яг шийдэх мөчид Сталин түүнийг өөрийнх нь зохиож, бэлтгэж, бэлэн болгосон ажилбараас нь хөндийрүүлж байна. Яаж бэлтгэсэн билээ, яаж хамаг нарийн ширийнийг мэдэж байгаа билээ! Гэтэл ингээд зайлуулж байна! Жуков Москва орчмын тулалдаанд ялсан, бас Сталинградын тулалдаанд ялахыг нь Сталин хүсэхгүй байна. Сталины сурсан наадам...

– Яагаад ийм шийдвэр зөв байх вэ? хэмээн Сталин дахиад ярьж эхлэв. – Яагаад гэвэл, хэрэв бид Ржев руу хоёрдугаар зэргийн хүн явуулах юм бол германууд үүнийг ердөө төөрөгдүүлж байгаа ажиллагаа байна гэж ойлгоно. Харин ажилбарыг Жуков өөрөө удирдаж байгааг мэдвэл үүнийг даацтай дайралт гэж үнэлээд, цэргээ өмнө зүгт шилжүүлэхгүй төдийгүй харин ч ийш нь татах болно. Ингэхээр, бидний Сталинградын зорилт ч хөнгөрөөд явчихна.

Жуков дуугарахгүй л байв.

Сталин түүн рүү муухай харсан чигээрээ үргэлжлүүлэв:

– Та яг миний авдаг шиг мэдээллийг авч байх болно. Та заавар өгч болно, санал дэвшүүлж болно. Та Сталинградын довтолгоог бэлтгэсэн, бид таныг түүнээс хөндийрүүлэх хүсэлгүй байна. Бүх зааврыг та бид хоёрын гарын үсгээр өгч байх болно.

Сталин Жуковыг дахин нэг харснаа,

– За ийм байдлаар хийцгээе хэмээн үгээ төгсгөв.

– Нөхөр Сталин, таны тушаалыг мэдлээ!

Асуудал отго жинсэндээ байгаа юм биш. түүнд отго жинс хэрэггүй. Гэхдээ ялалтын биежилт

нь ганцхан хүн байх ёстой. Жуковыг Москвагийн тулалдааны ялагч гэж үздэг. Маш сайн хэрэг. Том жанжин тухайлсан нэг тулалдааныг ялж байх ёстой. Гэхдээ хоёр дахь тулалдааныг, эргэлтийн, гол тулалдааныг ялна гэдэг бол... Үгүй ээ, Сталинградын ялалт Сталины нэртэй холбогдох ёстой.

Арван нэгдүгээр сарын 19-нд хойноос, 20-нд өмнөөс зөвлөлтийн 1 сая 103 мянган цэрэг довтолгоонд орлоо. Тэдний эсрэг бараг тийм тооны герман, румын, итали, унгар цэрэг зогсож байв.

Арван нэгдүгээр сарын 23-нд зөвлөлтийн цэргийн хоёр бүлэглэл уулзаж, Паулюсын армийг бүслэв. Гитлер Паулюст цэргийг нь бүслэлтээс гаргана гэж амлаад бүслэлтийг сэтэлж гарахыг хоригложээ. Гэвч бүслэлтийн хүрээг таслах аливаа оролдлого бүтсэнгүй.

Арван хоёрдугаар сарын турш Оросын өмнөд асар удам нутагт цус асгаруулсан тулалдаан үргэлжилж, зөвлөлтийн цэрэг германуудыг Донын цаад руу, баруун тийш хол ухрааж хөөв.

Арван хоёрдугаар сарын сүүлчээр Паулюсын армийг бүрмөсөн бут цохих төлөвлөгөөг хэлэлцэх явцад Сталин,

– Дайсныг бут цохих ажлын удирдлагыг нэг хүнд даалгах хэрэгтэй гэж хэлэв.

Энэ тухайд яригдах хоёр хүн байгаа: Сталингардын фронтын командлагч Еременко, Донын фронтын командлагч Рокоссовский.

Сталины хувьд энэ бол шийдэгдсэн асуудал. Киевийн тулалдаанд сүйрэл хүлээж зөвлөлтийн ард түмнийг хохироосон Еременкогийн бардам амлалтыг тэрээр мартаагүй. Сталинградын тулалдаанд ялалт байгуулж өөрийгөө цагаатгана гэж бодож байгаа бол горьдсоны гарз.

Бас нэг зүйл. Рокоссовский нэг юмаараа Тухачевскийг санагдуулдаг учир тэрээр түүнийг онцгойлон үздэг. Дайны өмнө баривчлаад тавьсан. тэрээр нэг удаа түүнээс энэ тухай асуусан. Рокоссовский тэгсэн гэж нотолсон. Тэгэхэд тэрээр,

– Суух цагаа мөн ч олж дээ гэж зэмлэнгүй хэлсэн.

Рокоссовский инээмсэглэсэн, тоглоом ойлгосон хэрэг, эр хүн. Дайнд ч дажгүй байлдаж байгаа, Тухачевскийгээс ялгаатай нь биеэ тоохгүй байгаа.

– Еременко Брянскийн фронтын командлагчийн хувьд өөрийгөө маш муугаар харуулсан. Бас даруу биш, сайрхуу зантай. Хоёр фронтыг нэгтгэж командлагчаар нь Рокоссовскийг томилох хэрэгтэй гэж Сталин хэлэв.

Нэгдүгээр сарын 10-нд Рокоссовский Паулюст бууж өгөхийг тулган шаардав. Паулюс тэр шаардлагыг хүлээж авсангүй. Зөвлөлтийн цэрэг довтолгоонд орж, Германы зургадугаар армийг дундуур нь тас огтлов. Нэгдүгээр сарын 31-нд өмнөд бүлэглэл, хоёрдугаар сарын 2-нд хойд бүлэглэл бууж өглөө.

Сталинградын тулалдаан хоёр зуу хоног үргэлжлэв. Энэ хугацаанд германууд Орост байсан

цэргийнхээ дөрөвний нэгийг алдав...

Сталинградад ялалт байгуулсны төлөө нөхөр Сталинд Зөвлөлт Холбоот Улсын маршал гэдэг цэргийн дээд цол олгов.

Одоо түүний нэрэнд бүх эрин зууны, бүх улс түмний жанжин гэдэг чимэг заавал нэмдэг ёстой болов.

Волга, Донын бүсэд дайсны цэргийг бут цохисны дараа зөвлөлтийн цэрэг германуудыг баруун зүгт холдуулан хөөж, Ростов, Новочеркасск, Курск, Харьковыг чөлөөлөв.

Гэтэл Воронежийн фронтын командлагч генерал Голиков дайрах бололцоогоо хэтрүүлж үнэлээд урагш тасарсан ангиудаа буцааж татаагүй учраас германууд сөрөг довтолгоонд шилжиж, Харьков, Белгород хоёрыг дахин эзлэв.

Сталин Жуковыг Москва руу дуудаж, түүний явж байгаад ирсэн баруун хойд биений ажил явдлын талаар хэдэн ёс төдий юм асуугаад, Харьковын бүс рүү очиж байдлыг засах тушаал өгөв.

Жуков Голиковын алдааг далимдуулан түүнийг албан тушаалаас нь халахыг шаардана, татгалзахад хэцүү гэдгийг Сталин ойлгож байсан учраас Жуковоос өрсөж өөрөө өөрчлөх нь зүйтэй гэж үзжээ.

– Бид Голиковыг өөр ажилд шилжүүлнэ. түүний оронд хэнийг тавих санал байна?

– Генерал Ватутиныг.

– Таарах нэр байна, ер нь тэгье. Та одоо нис.

Ватутин Воронежийн фронтыг тэргүүлж, Голиковыг Батлан хамгаалах ардын комиссарын боловсон хүчний асуудал эрхэлсэн орлогчоор томилжээ. түүний тэгж дэвшсэнд Жуков гайхсангүй. Сталин эрхлүүлдэг хүмүүсээ гомдоодоггүй хүн. Тэр муу Голиков яахав, чөтгөр алгадмар. Москвад цаас эргүүлээд л сууж байг.

Фронтын байдал тогтворжиж, намжмал үе эхлэв.

Жанжин штабынхан хэрхэн довлох тухай бодож байв. Сталины байнгын хүсэлт ч довтолгоон. Гэтэл Жуков дөрөвдүгээр сарын найманд Ерөнхий жанжны газар ирүүлсэн илтгэлдээ ингэж бичжээ:

“Ойрын өдрүүдэд манай цэрэг довтолгоонд орохыг оновчтой биш гэж үзэж байна. Тэгснээс хамгаалалтанд хориглон байлдаж дайсныг тамирдуулан, танкийг нь гаргуулж устгаад, дараа нь ерөнхий давшилт хийж дайсны үндсэн бүлэглэлийг бүрмөсөн гүйцээж цохивол дээр”.

Рокоссовский, Ватутин хоёр Жуковыг дэмжив.

Сэтгэлийн тэвчээр л шийднэ: хэн нь тэвчээр алдаж, эхэлж дайрах бол. Гитлерийн тэвчээр хүрсэнгүй. тэрээр 6 тоот шуурхай тушаалдаа:

“Цаг агаарын нөхцөл таатай болмогц энэ оны анхны довтолгоо болох “Цитадель” ажилбарыг хэрэгжүүлэхээр би шийдлээ. Энэ довтолгоо шийдвэрлэх ач холбогдолтой байх болно. Курскийн орчимд байгуулах ялалт бүх дэлхийн хувьд бамбар болно... Эрс шийдэмгий,

төвлөрсөн түргэн цохилтоор Курскт байгаа дайсны цэргийг бүсэлж устгах хэрэгтэй” гэж заасан аж.

Жуковын сэтгэлийн тэвчээр илүү чанга болж таарав. Ерөнхий жанжны газар түүний төлөвлөгөөг хүлээж авав. Гэхдээ Сталинд тал зассан нэг тайлбар хийжээ: Курскийн хамгаалалт бол аргагүйдсэн бус зориудын хамгаалалт. Германууд довглохгүй бол бид довглоно.

Сталин тэр өдөр Курскийн цүлхэнг хамгаалах төлөвлөгөөг баталж гарын үсэг зурав. Тэгтэл Берия яаралтай мэдээтэй хүрч ирэв. түүний сандарсан царайгаар Яковтой холбоотой юм байх нь гэж Сталин ойлгов.

Берия суулгүй,

– Нөхөр Сталин, Яковын үхлийн тухай танд дуулгах хүнд үүрэг надад оногдлоо гэж аяархан өгүүлэв.

Сталин сандал руу дохив.

– Суугаад ярь.

Берия суугаад хавтсаа нээв.

– Цаасгүй ярьж чадахгүй юү?

– Энд герман, англи нэрс байгаа...

– За яахав, ярь, ярь.

– Дөчин хоёр оны сүүлээр Яковыг Берлинээс гучин километр зайтай Заксенхаузены лагерьт аваачиж, тусгай тасгийн “А” байранд оруулсан байна. хэмээн Берия эхлэв. – Тэнд дайсан улсын удирдагчдын хамаатнуудыг суулгадаг юм байж. Байр нь том, дундын том өрөөрэй, хоол идэх тасалгаа, хоёр жорлон, хоёр унтлагын өрөөтэй. Нэг унтлагынх нь өрөө дөрвөн английнх гээд Берия хавтсаа харж, – Томас Кушинг... гээд унштал, Сталин,

– Тэдний нэр ус надад хэрэггүй гэж үгийг нь таслав.

– Нөгөө унтлагынх нь өрөөнд Яков, Василий Кокорин гэдэг өөр нэг зөвлөлтийн олзны хүн. Тэр өөрийгөө Молотовын ач дүү гэдэг юм гэнэ.

– Молотовт ач дүү бий гэж үү?

– Байхгүй.

– За, цааш нь.

– Яков сэтгэлийн гутагт автсан байж. Энэ бүтэн хагас жилийн хугацаанд түүнийг туж

байцааж байсан байна. Яков Жугашвили биеэ эрэлхэг тэвчээртэй, нэр төртэй барьж байсан байна.

– Биеэ нэр төртэй авч явъя гэсэн бол юу гэж олзлогдох вэ дээ гэж Сталин хэлэв.

– Би түүний олзонд байхдаа биеэ хэрхэн авч явж байсныг л илтгэж байна.

– түүний олзонд байсныг би мэдэж байна. Цааш нь.

– Эцэс төгсгөлгүй байцаалт түүнийг сульдааж тамирдуулсан байна. Бас өөр нэг нөхцөл байдал. Өмнөх лагериудад Яков бусад олзныхонтой сайн харилцаатай байсан бол Заксенхаузенд анхныхаа өдрөөс л англичуудтай дайсан болсон байна. Яагаад тэгэв? Яков тайван хүн, англичууд ч төлөв хүмүүс шиг л...

– Англи хүн болгон мөн чанараараа колоничлогч, тэдний хувьд дорнын аливаа хүн бүдүүлэг амьтан гэж Сталин хөмсөг зангидав.

– Таны зөв, нөхөр Сталин. Англичууд Яков, Кокорин хоёрыг ариун цэвэр сахихгүй байна, жорлон завааруулж байна гэх мэтээр хашгачин зүхдэг байж... Яковыг өөрсдийнх нь дунд коммунист ухуулга хийсэн гэж буруутгаж байж. Өдөр болгон хэрэлддэг байснаа дөрөвдүгээр сарын 14-нд бүр зодолдохдоо хүрсэн байна... Яков байрнаасаа гүйж гартал, харуул буц гэж шаардсан боловч Яков үгэнд нь ороогүй учир толгой руу нь буудаж алсан байна. Тэр харуулын нэр Конрад Харвик. Тэнд харуулын дарга Карл Юнглинг бас байжээ. Тэд нар алсныхаа дараа Яковыг оргох гэж оролдсон болгох гэж хүүрийг нь цахилгаан гүйдэлтэй утсан дээр хаясан байна. Германууд Яковыг алжээ.

Сталин өрөөн дотуураа чимээгүй хэд алхсанаа, Берияг сонжин хараад,

– Яков Жугашвили эх орныхоо өмнө тарьсан гэмээ үхлээрээ цайруулж гэж үзье. Авгайг нь суллаж болно гэв.

Курскийн цүлхэн орчмын намжмал байдал бараг зуу хоног үргэлжлэв. Хоёр талын хүч үндсэндээ тэнцүү (нэг нэг сая цэрэг, офицер), хоёулаа бэлтгэлээ базааж байв. Курскийн цүлхэнгийн өмнөд этгээдийг Воронежийн фронтын цэрэг, хойд этгээдийг Төв фронтын (хуучин Донын фронт) цэрэг хамгаалж байгаа. Командлагч нь Рокоссовский хэвээр. Тэнд, Арван гуравдугаар армийн инженерийн цэргийн штабын бэхлэлтийн байгууламжийн хэлтэст Варя одоо алба хааж байгаа юм. Инженер-ахмад цолтой, мөрдэс нь дөрвөн таван хошуутай.

Германууд Курск мужийг хоёр дахин эзэлсэн, ширүүн тулалдаан болсоор байгаа. Олон хот сүйдэж, тосгон гацаа шатаж, байшингийн ормон дээр пийшингийн яндан ёрдойлцоно. Инженерийн цэргийн штаб, жижигтээ болж бүтэн үлдсэн нэг гацаанд байрлажээ. Орон байр ховор, гэхдээ Варяг ганц бүсгүй хүн гэж тусдаа байр олж өгсөн нь цонх нь газартай бараг чацууртлаа суучихсан хариугүй жаахан модон байшин.

– Өөр юу ч олсонгүй, гэрийн хоёр хөгшин пийшин дээрээ унтана, танд гол өрөөгөө өгнө гэж байр зохицуулагч тайлбарлав.

Варя орж хараад: “Аятайхан л байр байна” гэжээ.

Гэрийн эзэн Афиноген Герасимович 56-тай болж таарав. Айхтар үрчлээтэй ясархаг нүүр, буурал суусан шодон сахал, эвэршсэн хатангир гар энэ тэрийг нь хараад Варя түүнийг илүү өтөл гэж бодсон аж. Сэмэрсэн пиджактай, нөхөөстэй өмднийхөө түрийг цойлдсон хуучин эсгий гутал руугаа чихэж өмсчихөөд,

– Гадаа дулаарчихаад байхад миний хөл даараад байх юм гэж гомдоллоно.

Тамхи гэж өвс ч юм уу, нэг муухай юм татна. Варя өөрт ноогдох ёстой тамхиа түүнд авч өгдөг болов.

– Та чинь тамхи татдаггүй шүү дээ гэж хүнсний дарга гайхав.

– Одоо татдаг болсон.

Өвгөн тамхитай болсондоо баярлан толгой сэгсрэнэ:

– Өлөн хүнд ямар сайн байхав, гэхдээ тамхигүй бол ерөөсөө үхсэнтэй адил. Утаагаа сорчихоор чинь амьдрал ч хөнгөрөөд явчих шиг болно. Орос хүн тамхигүй байж заяа нь таарахгүй.

– Бас германууд ч татна шүү дээ гэж Варя өчив.

– Нээрэн татна, цадтал гахайлчихаад бас тамхиар цэнгэх хэрэгтэй, тэдний тамхи сайхан үнэртэй шүү. Зарим герман ой нь гутсандаа тамхи татна, албадаж араатан шиг болгож байгаа юм чинь: шатаа, түймэрд, залуу хөгшингүй ал, бүр нялх амьтныг ч ал гээд. Шатаж байгаа байшингаа унтраах гэвэл герман тэр дор нь чамайг буудчихна... Манайхны олзлогдогсдыг

гээд бодоход, хичнээн хүн өлсөж, хичнээн хүн элдэв тахлаас үхсэнийг тоолохын арга байхгүй, өвчтэй, шархдсан хичнээнийг буудаж хороосныг бас тоолшгүй, эрүүлийг нь туугаад явчихна... Туугдаж яваа өлөн амьтанд хэрчим талх атгуулчих юм бол нөгөөхийг чинь чамтай хамт буудчихна. Тэднийг бид тэгнэ чинээ санаж байсан бил үү?

Варя руу хяламхийснээ, үгээ залруулав:

– Мэдээж дайсан, гэхдээ хүн шүү дээ, бид тэгж бодож, тэгж ярьцгааж байсан. Орос цэрэг нялх хүүхдийг ална гэж байх уу? Тэгвэл герман алж байгаа юм.

Өвгөн бодлогошрон, хуруугаа шүлсдэж байгаад тамхиа унтрааж дараа татахаар пял дээр аятайхан тавина...

– Би дэлхий нэгдүгээр дайнд байлдаж явлаа, иргэний хүн амд халдана гэж байхгүй, хатуу цээртэй. Герман ч бас халдахгүй. Арван найман онд герман Украинд байсан, энүүхэнд шүү дээ. Гэтэл одоо яадаг болж гээч! Залуусыг Герман руу ажилд хөөж байна. Ямар гээчийн тийм эрх байна? Манайхан ч бас тэнэг толгойнууд биш л дээ: харахгүй юу, би маажууртай гэгчихнэ. Тэднийхний эмч үзнэ, үнэхээр, гар хөл, цээж бөгс гээд, уучлаарай хамаагүй ярьж байна, хамаг бие нь хаа сайгүй хамуу. Тэд чинь хамуутайг авахгүй, айна. Тэгээд хүмүүс зориуд бие биендээ хамуу халдаадаг болсон, хамууны нян чинь амархан халдана, хаа л бол хаа амьдрах чадвартай, гэтэл саван гэдэг юм аль дайны эхнээс хойш нүдний гэм... Айлын нэг л хүнд нь халдлаа бол сар гэхэд тэднийхэн бүгдээрээ маажуур эхэлнэ, манай тосгон эмгэн бид хоёроос бусад нь цөмөөрөө хамуутай, бид хоёр хоёулхнаа суудгаас гадна, тэд нартай гар барьдаггүй юм. Бас ариун цэврийг сахих гэж хичээнэ.

Нээрэн ч тэднийх цэвэрхэн, нэг аятайхан үнэртэй өвстэй.

– Энэ чинь эмчлэгдэх үү, хамуу чинь? гэж Варя асуув.

– Эмчилж яах юм, Герман руу туугдах гэж эмчлэх үү? Бага шиг загатнуулах гэж нэг юм түрхэнэ, байж ядтал загатнана шүү дээ, хамуу чинь. Германыг хөөсний дараа аяндаа эдгэрцгээсэн, хугацаа нь болохоор тэр. Жирийн хүн амыг ийм дээр нь хүргэсэн дээ. Түрүүчийн дайнд бол тийм юм ёстой байгаагүй. Орос, герман гэлтгүй, аль аль нь арай зөөлөн сэтгэлтэй байж. Тэр дайны дараа л бүх юм эхэлсэн. Улаантан нь цагаантнаа, цагаантан нь улаантнаа. Жишээ нь, чи хөрөнгөтний нэртэй байлаа гэхэд чамайг хана руу тулгаад буудчихна, пролетарийнх бол нөгөө хана руу тулгаад бас буудчихна. Тэгээд л ард түмэн дошгирч хатуу сэтгэлтэй болчихлоо... Уул нь иргэний дайн дуусмагц бүх юм нам гүм болчих шиг болсон юм. Ажил явдал ч урагшилж эхэлсэн. Цахилгаан гэрлийн шугам татсан, нөхөр Владимир Ильич Ленинд зориулан “Ильичийн дэнлүү” гэж нэрлэдэг байсан юм. Уншлагын байшин гэж бий болсон, сургууль нээсэн, өглөө нь хүүхдүүд, орой нь өвгөд ном үзнэ, бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах гэдэг ажил байлаа. Дажгүй, боломжийн аж төрцгөөж байлаа... Дараа нь, гучин онд бүх юм гажуудаад эхэлсэн, ард түмэн дахиад дошгирох нь тэр, буруутай, буруугүй хамаа байхгүй, гарт өртсөн болгоныг толгой дараалан эрэмдэглэж байсан. Одоо бол энэ дайн. Мэдээж, “бид ялахдаа л нэг ялна” гэж хэлсэн байгаа, хэрэг дээрээ тийм л болно, харин тэр ялалтын дараа яаж сэхэх тухай би хэлж мэдэхгүй байна.

– Аж ахуй сэргэхгүй гэж та бодож байна уу?

– Яагаад сэргэхгүй гэж? Модон байшингуудыг галдсан, дахиад барьчихад төвөг нь юу сан билээ? Харин тэр байшинд хэн суух вэ? Энэ дайнд олон сая хүн алга болно. Амьд үлдсэн нь тосгонд буцаж ирэх нь юу л бол. Түрүүчийн дайны дараа цэргүүд гэртээ харих гэж тэмүүлж байсан, газар амласан учраас тэр. Тэгвэл одоо юу руу явах вэ, юу руу буцаж очих вэ? Нөгөө хөдөлмөр өдөр рүүгээ, нөгөө данс бөглөдөг зураас руугаа эргэж ирэх үү, зураасаар хоол хийхгүй шүү дээ, нөгөө паспорт ч байхгүй хамтралынхаа байдал руу эргэж ирэх үү? Үгүй ээ, тосгонд эргэж ирэхгүй. Үйлдвэрт машин эвдэрлээ гэхэд өөрийг тавьчихна, тосгонд тариачин эрийг хэнээр солих вэ? Хэнээр ч солихгүй. Тийм учраас тосгон бол, хэрэг дээрээ, мөд сэргэхгүй. Тосгонгүй бол ямар юмных нь Орос байхав. Ер нь ч хөдөө аж ахуйгүй аргалаад байдаг улс гүрэн гэж байдаггүй байлгүй. Тийм учраас одоо ямар гарц, ямар учиг бий болохыг ойлгох арга алга, энэ тухай хэн ч мэдэхгүй. Ийм л байна даа, Варвара Сергеевна.

Хоёр хөгшин юугаар, яаж аж төрдгийг ойлгоход хэцүү. Төмс, байцаа тарина, идэшний ногоогүй яаж хоног төөрүүлэх вэ. “Цадгал идэхгүй, гэхдээ өлбөрч үхэхгүй” гээд Евдокия Карповна өвгөн рүүгээ онгосон харц илгээнэ. Тэдний ядуу зүдүү байдал бол эртний, ижил дасал болсон аж төрөл, орос тариачин үеийн үед ингэж л аж төрж ирсэн. Хувь заяандаа захирагддаг нь ч бас л олон үеийнх. Хавь ойрт нь буун дуу гарлаа гэхэд Афиноген Герасимович эргэж ч харахгүй, буудах л гэж дайн хийнэ биз дээ гэх маягтай. Хэний онгоц нисч байгааг андахгүй, “манайх” эсвэл “Гитлер нисч байна” гэнэ, тосгоныг бөмбөгдөх эсэх тухайд, яах л санж вэ гэсэн мэт тэр талаар бодох ч үгүй.

Варя дивиз рүү байсхийгээд очно. Явахдаа хуурай хүнсээ гэрийн эзэддээ үлдээнэ: дивиз дээр өөрийг нь хооллочих юм чинь. Афиноген Герасимович жигнэсэн махны нөөшийг ажин харж,

– Америкчууд нөөшийг гоё хийх юм. Германууд ч бас нөөштэй, мөн ч олон лааз энүүгээр новширч байгаа, гадна талаасаа эднүүс шиг гоё биш, амтыг нь бол мэдэхгүй, манийг дайлж байсангүй. Варвара Сергеевна, та өөрийгөө ингэж тонож болохгүй, бид хоног төөрүүлчихнэ, харин та бол залуу хүн, юм идэж байлгүй болохгүй гэнэ.

Варяг буцаад ирэхэд нь хуурай хүнсэнд нь огт гар хүрээгүй байх. Тэгэхээр нь цуг сууж байгаад, нөөшийг албадан онгойлгуулж, май загасыг янзлуулна, тэгсэн цагт нөгөө хоёр нь магтан байж амтархан иднэ.

Евдокия Карповна лаазыг угааж арчаад пийшин дээр тавьж: “Энүүнд чинь толь шиг харж болох юм, гоё алтлаг” гээд Варяг энхрий харцаар ширтэнэ.

– Чи ч бас алтан охин, сайхан хүүхэн, нөхөр чинь бас цэргийнх үү?

– Цэргийнх.

– Харин хүүхэд байхгүй юм байж, бурхан хайрлана даа. Өнгөрсөн дайнд хүүхнүүд зөвхөн сувилагч л хийж байсан, чам шиг ийм цэрэг хувцастай, гар буутай дарга гэж огт байхгүй. Одоо эр хүн дутдаг юм уу, хаашаа юм?

– Иргэний дайны үеэс ийм болсон юм гэж Афиноген Герасимович тайлбарлана. – Тэгэхэд хүүхэн дарга нар бишгүй гарч ирсэн. Манай энд нэг комиссар хүүхэн байсныг санаж байгаа биз дээ, савхин дээлтэй, гар буутай, еврей бил үү, армян бил үү, шудрага, дайчин хүүхэн, элдэв зүй бус юмыг тас цохино, хэрхэвч гаргуулахгүй.

– Чи өөрийгөө хямгадаж яв, хэрэггүй юм руу дэмий битгий зүтгэлж бай гэж Евдокия Карповна Варяд сургамжлана.

– Зүтгэлэхгүй ээ гээд Варя инээд алдана.

тэрээр нэг өглөө штаб ругаа явахдаа санаандгүй эргэж харжээ. Тэгсэн чинь Евдокия Карповна араас нь загалмайлан залбирч байж. Варяг эргэж харна гэж бодоогүй учраас санаа нь зовоходоо гараа ч буулгалгүй тэр чигээрээ хөшчихөж.

Варя Төв фронтын штаб руу, Телянертэй уулзах гэж Свобода гацаа руу бас очно. Телянер хэдийнэ дэд хурандаа цолтой болсон, дүрэмт хувцас нь бас л биенд нь олигтой таараагүй бараг үлхийж байгаа хэдий ч мань хүн энд ч гэсэн маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа. Хамгаалалтын байгууламжинд зориулсан төмөр бетон хийцийн үйлдвэрлэлийг зохион байгуулснаар эд ангийг газар дээр нь аваачаад шууд угсардаг болсон аж.

Варя тийм эд ангийг Арван гуравдугаар армид хүргэх ажлыг зохицуулж, угсралтад нь хяналт тавина. Хүргэх ажил саатна, эд анги нь заримдаа дутуу ирнэ, элдэв доголдол гарахгүй өдөр гун ховор. Тэгээд утасдахгүй газаргүй, юуны өмнө Телянерт утасдаж, цаадах нь тус болж аминд нь орно.

Арван гуравдугаар армийн хил 32 километр, дөрвөн дивиз тус бүрийнх найман километр. Хоёрдугаар зурваст бас хоёр дивиз байгаа, нэгнийх нь командлагч Максим. түүний штаб тосгоны ойролцоо бяцхан төгөлд байх. Варя тэргүүн шугам руу явахаараа түүний тэнд бууна, тэндээс аль ч дивиз рүү ойрхон, Максим түүнд машинаа харамлахгүй өгнө, өдрийн сүүл рүү утасдахад мань хүн “виллис”-ээ явуулчихна. Варягийн дарга хурандаа Колесников: “Та чинь миний цэрэг юм уу, генерал Костины цэрэг юм уу?” гэж тоглоом хийнэ.

Варяг Костины хүр охин дүү гэдгийг тэрээр мэднэ, ер нь тэр тухай нийтээрээ мэднэ. Хэдий тийм ч элдэв яриа гарах вий хэмээн Максим Варяг өөрийнхөө хамгаалалтын байранд шөнө хонуулахгүй, цаадуул нь нэг газар зоорь олж өгнө, тэр нь бөхийж явахаас аргагүй намхан адартай, давчуу ч гэсэн хонох төдийд бол дажгүй оромж.

Максим болох гэж буй тулалдаанд бэлтгэн, өдөржин ангиудаараа яваад орой буцаж ирмэгц штабынхнаа цуглуулж үүрэг даалгавар өгч, илтгэл мэдээллийг нь сонсоно. Варя ийм зөвөлгөөнд заримдаа сууна. Максим хүмүүстэйгээ дандаа ажил хэрэгч, энгийн, итгэмжилсэн байдлаар ярина.

Зөвөлгөөний дараа хүмүүс тарж явцгаана. Штабын дарга, улс төрийн орлогч, арын алба эрхэлсэн орлогч, Варя энэ тэр үлдэнэ. Заримдаа армийн юм уу, фронтын төлөөлөгч ирсэн бол бас үлдэнэ, Максим удирдлагатай хэл амаа аятайхан ололцоно.

Максимын хамгаалалтын байр том, хуурай, эвтэйхэн, тэнд оройн хоол идэцгээнэ. Хоолны үеэр бас л ажлаа ярьцгаана, Варя тэнд удахгүйг хичээн, тэгсхийгээд гарч, газар байрандаа очиж хоноод, өглөө эрт хилийн шугам руу эсвэл штабын байр руу явна.

Заримдаа Максимтай хоёулхнаа ярилцах боломж олдоно. Максим энд улс төрийн яриа зохисгүйг Варяд сайхан сэтгэлээр, гэхдээ тов тодорхой, хатуу ойлгуулсан, Варя ч тийм яриа сэдэхгүй. Москва, Арбат, байшин энэ тэрээ дурсацгаана, Максим Нинагийн захианаас сонин болгож ярина, Ванягаа ухаантай жаал гэж магтана. Нэг удаа зальжин харж байгаад,

– Би энд саяхан нэг хүнтэй уулзсан. Хэн гэдгийг чи хэзээ ч таахгүй гэжээ.

– Хэнтэй тэр вэ?

– Саша Панкратовтой.

– Сашатай юу? Чи хаана түүнтэй уулзаав?

– Над дээр орж ирсэн юм. Чиний сууж байгаа наад вандан дээр чинь сууж байлаа шүү дээ.

Варя түүнийг хүлээзнэн харав.

– Наад сандал дээр чинь сууж байсан юм гэж Максим дахин хэлээд инээвхийлэв. – Хүрч халдахын аргагүй том дарга болсон, фронтын штабт байгаа!

– түүнийг жолоочоор дайчлагдсан гэж Софья Александровна надад ярьж байсан.

– Тэр чинь үнэн. Жолооч байж байгаад, Москвагийн тулалдаанд онцгойрч, тэгээд офицерийн цол авсан, маршал Жуков биечлэн олгосон гэж байгаа, ямар вэ дээ?

тэрээр Сашагаар одоо ч бахархаж байгаагаа нуухгүй байв.

– Гвардийн инженер-хошууч, манай фронтын авто тээврийн газарт алба хааж байгаа. Аль хэцүү газар руу л мань хүнийг явуулж байгаа гэж ойлгож байна. Саша бол лут ажилтан, туршлагатай, ажлыг дуусгаж чаддаг хүн.

– Намайг энд байгаа гэж хэлсэн үү?

– Хэлэлгүй яахав. Танил найз нараа бүгдийг нь дурсан ярьцгаасан.

Макс өөрийнх нь армийн инженерийн цэргийн штабт Варя байгаа гэдгийг Сашатай анх уулзангуут хэлсэн. Өөдөөс нь харж суучихаад: “Ингэж уулздаг юмаа бас! Арван жил бараагаа харалцсангүй, аан!” гээд толгой сэгсэрч байсан. Сэтгэл нь гойд хөдөлсөн, хуучин нөхөрлөл зэврэнэ гэж байхгүй, Варя Алс Дорнод руу тэд нар дээр яаж нэг жаалыг аваачиж өгсөн, түүнийг Саша тэр хоёрын хүүхэд, бид л өсгөж бойжуулах болж дээ гэж байснаа хүртэл яримаар санагдсан. Гэвч Нинагийн: “Варя жинхэнэ ёсоор ганцхан Сашад л хайртай байсан гэж надад санагдах юм” гэж байсан нь ашгүй санаанд ороод, тийм нарийн нандин юмыг хөндөхгүй байх нь зүйтэй гэж шийдсэн. Харин Варя хүнтэй суусныг дурдсан, дайны өмнө тэднийд очсон, байр нь маш гоё, нөхөр нь алдартай уран барилгач, одоо хошууч генерал, сайхан амьдарцгааж байгаа гэж хэлсэн. Саша бүгдий нь тайван сонссон, элдэв юм асууж шалгааж, тодруулаагүй, тэгээд Варягийн сэтгэл алдаж байсан нь аль улирсан үеийн явдал, энэ бүхэн хүүхэд ахуй нас гэсэн бодол нь Максимд лавширчээ. Тийм учраас Сашатай уулзсан тухайгаа Варяд ердийн байдлаар тайван яриад, жаахан охин байхдаа Сашад сэтгэл алдарч байсан бил үү, тийм биз дээ? гэх маягтай нүдээ зальжин ирмэсэн.

Харин Варя тэр үгийг нь яаж хүлээж авсаныг мэдрээгүй. “Чи намайг энд байгааг хэлсэн үү?” гэдэг бол санаандгүй асуулт биш. Хүүхнүүд бодол дурсамждаа их соргог ханддаг бололтой юм. За яахав, том улс, учраа олцгооно биз...

За ингээд Саша энд байж байх нь. Өөрийг нь хаана байгааг бас мэдэж байх нь. Фронтоор хэрэн явж байдаг, тэдний армиар ирж очдог юм чинь, өөр дээр нь ч ороод гарч болох. Зүгээр

уулзаад гарах гэж. Тэр хоёрыг холбож байгаа юм зөндөөн шүү дээ. Өөрөө хүнтэй суусан нь ямар хамаа байна, найз нөхөд байж болохгүй гэж үү? Өөрт нь илүү дутуу ямар ч санаархал байхгүй, болсон бүх юмтай эвлэрсэн, амьд мэндэд нь нэг харах юм сан. Фронтод хүн болгон танихгүй ч байсан нутгийнхаа хүнтэй уулзах гэж тэмүүлдэг. Гэтэл Саша тэр хоёр... Өнөөдөр амьд байна, маргааш байхгүй болчихно, ийм аймшигтай дайн, боломж байгаа бол, магадгүй эцсийнх ч байж мэднэ, уулзахгүй байна гэдэг чинь юу гэсэн үг байхав. Зүгээр л: “Сайн байна уу, Варя, чамайг энд байдаг гэж мэдээд, ороод гарахаар ирлээ” л гэнэ биз. Тэгэхэд нь: “Юун сайн юм бэ, чи ёстой гоё шийдэж, Макс надад чиний тухай ярьсан, тэгээд чамайг ирнэ гэж харж байлаа” гэж хариулна. Жаахан сууж ярьцгаана, тэгээд Саша яваад өгнө, удаан ч явж магадгүй, тэр хоёр дахиад огт уулзахгүй ч байж магадгүй, дайн болж байгаа юм чинь, хэдий тийм ч тэгж уулзвал сэтгэл хөнгөрнө, сэтгэлд гэгээ орно, сэтгэлийн маш том дарамт арилна.

Гэтэл Саша ирдэггүй ээ. Варя өөрөө түүн рүү очихоор шийдэв. Хүн гайхах юм юу байна? Фронтын штабаар орсон, тэгээд чам руу ирлээ л гэнэ. “Сайн байна уу, Саша...”

Гэвч зургаан сарын эх гэхэд заагийн дагуух байгууламжийн үндсэн ажил дуусч, бүх бичиг баримтаа ёсчлон бүрдүүлсэн учир фронтын штаб явах шалтаг алга болов. Гэсэн хэдий ч Варя Телянерт утасдаж, өөрийг нь ямар нэг шалтгаар дууд гэж хэлэхээр шийдэв. Тэгсэн чинь Телянер эзгүй болж таараад, хурандаа Свинкин утас авч, Телянер гурав хоногийн дараа ирнэ гээд, өөрөө тус болох юм байхгүй юм болов уу гэж асуужээ.

– Байхгүй ээ, баярлалаа, гойдын юмгүй, би Давид Абрамовичоос нэг юм тодруулах гэсэн юм. За яахав, гурав хоногийн дараа утасдая гэж Варя хариулав.

Варя Телянер руу очих битгий хэл утасдаж ч чадсангүй, тэгэхээр Саша руу ч яаж очих вэ дээ.

Зургадугаар сард фронт дээр байдал хурцдаад ирлээ. Агаарын ширүүн тулалдаан үргэлжилж, Ерөнхий жанжны газраас германы довтолгоо долдугаар сарын 2-нд эхэлж магадгүй гэж анхааруулаад, цэргийг байлдааны бүрэн бэлэн байдалд оруулж, инженерийн цэргийн штабын ажилтнуудыг байр байрандаа байхыг тушаажээ.

Долдугаар сарын 2-нд германууд довтолсонгүй. Юм жаахан тайвшрах шиг болсон ч Варя Телянер рүү өөр шалтгаанаар очиж чадахгүй болов.

Арван гуравдугаар армийн зүүн жигүүрийг эзэлж байгаа 15 дугаар дивиз өөрийн хуваарьт хэсгээс 132 дугаар дивизэд шилжүүлж өгсөн бөгөөд тэднийх зарим байгууламжийн чанар муу байсан гэж гомдол гаргажээ. Тиймэрхүү үл ойлголцоон фронт дээр бишгүй гардаг, тухай бүр газар дээрээ шийдэгддэг билээ. Гэтэл 132 дугаар дивиз 70 дугаар армийн бүрэлдэхүүнд ордог, хоёр армийн уулзвар дээр, хамгаалахад хамгийн эмзэг газар байрлаж байгаа юм. Тийнхүү тэр зөрчил арми хоорондын маргааны шинжтэй болжээ.

Энэ асуудал сая үүссэн юм биш, эхлээд дивизийн хооронд, дараа нь армийн хооронд маргасаар, хэлэлцээр байтал нэг мэдэхэд бүтэн сар өнгөрч, фронтын штабаас: “Учрыг олж, зөрчлийг арилгаж, дүнг илтэг. Хэрэгжүүлэх хугацаа 5 хоног” гэсэн захирамж иржээ.

Варяг түүний дарга хурандаа Колесников дуудав. 15 дугаар дивизийн хилийг Варя хянаж

байсан, түүнд бүх бичиг баримт байгаа. Наргиан, хөгжөөнтэй байдаг Колесников энэ удаа ямар ч наргиан, хөгжөөнгүй байж. Варяд фронтын штабын захирамжийг өгч,

– Та унш гэв.

Варя уншаад дал мөрөө хавчив.

– Манай дивизэд гомдол санал байгаагүй, хөршүүд л гэнэт тэгж дээ.

– Мэрэгжил нэгт Витвинин маань ийм нөхөрсөг тус хүргэж байна. Би одоо түүнтэй ярина.

Хурандаа Витвинин Далдугаар армийн инженерийн цэргийн дарга.

Утас хангинаж, Колесников авлаа. Хурандаа Витвинин ярьж байгаа аж. Тэд ямар ч арми, дивизийн дугаар, байрлалыг дурдаагүй боловч Варя тэдний яриаг бүгдийг ойлгож байв.

– Манай төлөөлөгч маргааш гарна, өөрийнхийгөө явуулаарай гээд Колесников утсаа тавив. – Өөрт нь хэлэлгүй гомдол мэдүүлсэн байна гээд өөртөө буруу өгөхгүй байна, бид энэ мэтийг мэдэлгүй яахав дээ... За тэгэхээр, Варвара Сергеевна... Өнөөдөр хоёр машин маань гадуур явж байгаа, бүх бичиг баримтаа аваад, маргааш өглөө 15 дугаар дивизийн штабт оч, тэндээс дивизийн инженерийн хамт газар дээр нь очих хэрэгтэй, би түүнд хэлчихнэ. Ямар нэг дутуу юм байвал тэрийг нь засч гүйцээх хэрэгтэй, би тийм шийдвэр дивизийн инженерт өгсөн.

– Бидний дутуу хийсэн юм гэж тэнд байхгүй гэж Варя зөрөв.

– Тийм байж магадгүй... Гэхдээ зөрчлийг арилгах хэрэгтэй, та тэдний төлөөлөгч гарын үсэг зурсан акт авчирч өгөх ёстой. Манайх уу, тэднийх үү, хамтрах уу, хэн гүйцээж хийх тухайд наймаалцах хэрэггүй, гол нь актгүй буцаж ирж болохгүй. Танд 15 дугаар дивизийн штаб хүртэл машин өгч байна, тэндээсээ буцаагаарай, цаашаа тэдний машинаар явна, штаб руу эргэж ирэхээрээ утасдаарай, би таныг авах машин явуулна. Замын машин олвол бүр сайн хэрэг.

Варя долдугаар сарын 3-ны өглөө эрт дивиз рүү гарав. Дассан сурсан зам, цэргийн ачааны машинууд, штабын хөнгөн тэрэгнүүд, шалган нэвтрүүлэх цэгүүд, манай онгоцнууд нисч байна, германых, яагаад ч юм, харагдахгүй байна. Варя буцахад нь Колесников машин ирүүлэхгүй байж магадгүй гэж болгоомжлоод, Максимд түүний тус хэрэг болж мэднэ гэж урьдчилан хэлэхээр тэднийхээр дайрав.

Максим хамгаалалтын байрныхаа гадаа машиныхаа хажууд зогсож байгаа нь нэг тийш явах гэж байгаа хэрэг.

Варяг хаашаа явж байгааг сонсоод, дургүйлхсэн янзтай,

– Чамаас өөр явуулах хүн байдаггүй юм уу? Танай инженерүүдийн дотор эр хүн байхгүй юм уу? гэв.

– Миний хариуцсан хэсэг.

– Тэр хамаагүй. Байдал түгшүүртэй байна. Өчигдөр довглоно гэж хүлээж байсан боловч довтолсонгүй, гэхдээ хэзээ хэзээгүй дайрч магадгүй.

– Одоо юу ярих вэ, Максим, би энд ирчихээд байхад чинь. Манай дарга надад машин ирүүлэхгүй байж магадгүй гэж санаа зовоод. Юм болвол чи над руу унаагаа явуулчихаарай, эндээс бол би аргалаад буцчихна.

– “Юм болвол” шүү гэж Максим бувгнаад, – Явуулалгүй яахав гэв.

– Би: Иванова утасдаж байна гэж хэлнэ. Тэгэхээр чи намайг 15 дугаар дивизийн штабт байгаа юм байна гэж ойлгоорой. За юу?

– За, харин намайг байхгүй бол штабын дарга руу юм уу манай дивизийн инженер Велижановт утасдаарай, би тэдэнд хэлчихнэ. Чи тэнд хэр удах юм?

– Мэдэхгүй. Ямар нэг юм гүйцээж хийх хэрэг гарвал гурав, дөрөв хононо.

– Шөнө анги дээр үлдэх хэрэггүй, дивизийн штаб руу ирж бай.

– Би манай дивизийн дэвсгэр дээр биш, Зуун гучин хоёрдугаар дивизийнх дээр байх юм.

Саша Варяг Арван гуравдугаар армид алба хаадаг гэж дуулангуутаа түүн рүү явжээ. түүнд юу гэж хэлэх тухайгаа ер бодсонгүй. “Чамайг энд байгааг мэдээд, уулзая гэж ирлээ”. Тэр хоёрын хооронд байсан бүх юм, нарийндаа бол байж болох байсан бүх юм, бүтээгүй, энэ бүхэн улирч одсон. Захидал, уулзах горьдлого, хардлага, гомдол энэ бүхэн алга болсон, цаг хугацаанд ууссан, арван жилийн өмнөх залуу цагийн, гэгээлэг юм л гагцхүү үлдэж. Тэгэхэд тэрээр нэг удаа тэдний өрөөнд сууж байсан, сурагч охин Варя яаж өвдөг дээрээ хичээлийн “будаагаа” бичдэгээ харуулж асан. Бас өсгөлөн халуун зангаар: “Би бол тэд нарыг өөрсдийг нь хөөчих байсан, хүнийг л цааш нь харуулахаас өөр юм боддоггүй муусайн новшнуудыг” гэж байсан.

Ердөө: “Калининаас утасдсан тэр нэг яриаг уучлаарай, амьдрал нэг л олиггүй байсан юм” гэж хэлж ч магадгүй. Гэхдээ өөрийгөө зөвтгөх хэрэгцээ бараг гарахгүй, Варягийн хувьд тэр цаг нисэн одсон. Гэхдээ залуу цагийн, улирсан үеэс мэдэх хүнтэйгээ уулзахад аятайхан байх байлгүй, өнөөгийн энэ цусанд хутгалдсан цагаас харахад тэр үе ёстой сайхан, ёстой баяртай үе гэхээр харагдаж буй...

Тэгсэн чинь Варя эзгүй, штабынхан нь түүнийг цэргийн байрлалаар явж байгаа гэжээ. Дараа нь хоёр долоо хоногийн турш Сашад Арван гуравдугаар арми явах шалтаг ч байсангүй, цаг ч байсангүй. Богинохон хугацаанд тэдний фронтод их буу, танк, сум хэрэгсэл, шатахуун, хүнс, хувцас хунар ачсан бараг зуугаад мянган вагон, тэвш иржээ. Энэ нь авто тээврийн албаныхны хувьд бол өдөр болгон хэдэн мянган гүйлт хийнэ гэсэн үг. Найгүй замаар, дайсны бөмбөгний доогуур, гурав, дөрвөн зуун километр явна. Сэлбэг хэрэгсэл, дугуй, бензин дутагдана, тэгсэн ч гэсэн “Алив бушуул, бушуулаач!” л гээд байна. Хэн ч ямар ч тайлбар хүлээж авахгүй, ямар зовлон бэрхшээл байгааг ойлгохыг хүсэхгүй.

Саша удирдах газрынхаа бусад инженерийн нэгэн адил шинэ машин хүлээж авна, батальон, суман бүрдүүлнэ, явуулын засварын газар зохион байгуулна, төмөр зам руу очно. Олон машин бөөгнөрвөл дайсны нисэх хүчний анхааралд өртдөг болохоор жолооч болгон цоройж гарах зүтгэлж, тэднийг журамлах хэрэг гарна. Саша тэгж чадна, нэгэнт сурсан ажил, хоёр жилийг фронтод авсны хэрэг юу билээ, цаадуул нь ч үгэнд нь орно.

Сталинградын хавиас олж авсан “оппел”-ио засч сэлбээд, заримдаа албан тушаалын машинтай байж болно, заримдаа болохгүй гэх учир үнэн худлаа ярьж байгаад өөртөө үлдээж дөнгөсөн, түүгээрээ л давхиад байна. Бас жолооч Николай Халшиныг өөрийнхөө дэргэд байлгаж байгаа, олон тулалдаан, олон шинэчилсэн зохион байгуулалт энэ тэрийн дараагаар нөгөө авто сумангаас үлдсэн нь ганц тэр. Овсянников Пронскт өнгөрсөн, амий нь аварч чадаагүй, дөнгөж амьдралын захад хүрч байсан, ёстой сайн залуу учраас Саша их харууссан. Юхновын байлдаанд Чураков, Руслан Стрельцов хоёр алагдсан. Николай амьд мэнд гарч, одоо өөрийнх нь жолооч, туслах, зарлага гэхчлэн бүх юмыг нь хийнэ, үнэнч, найдвартай хүн.

Саша давтан шалгалт өгөхдөө яалт ч үгүй биеийн байцаал бөглөсөн. Бас ял заагдаж явснаа яалт ч үгүй бичсэн, гэтэл өөнтөглөж гоочлоогүй. Ял заагдаж явсан нь ганц мань хүн биш, эргэн тойронд нь зэвсэгтэй хүмүүс байгаа болохоор “хамгаалахынхан” болгоомжтой ханддаг байсан. Жуковын нэр ч нөлөөлсөн байж магадгүй, Сашаг өөрөө биечлэн байлдагчаас офицер

болгосон шүү дээ.

Саша дөнгөж долдугаар сарын эхээр Арван гуравдугаар арми руу очиж амжив. Америкийн “студбеккер”, “шевроле”, “дожь” гэдэг шинэ машинууд ирж, тэдгээрийг хамгийн сайн жолооч нарт хуваарилаж байв. Армид жолооч байнга дутагдана, тэгтэл торгуулийн батальоноос жолооч авах зөвшөөрөл ирэв. Тэндээс жолооч авах журам маш хатуу, гэхдээ жолооч хэрэгтэй, тэгээд ч цөөн ч болохноо хэдэн хүний амь аврах юм чинь яая гэхэв.

Саша хоёр дэслэгчийн хамт Арван гуравдугаар армийн байршилд байгаа торгуулийн батальон руу явжээ. Нэгдүгээр суманг жагсаалаа. Саша: “Жолооч нар нэг алхам урагш!” гэж командлав. Суман тэр чигээрээ урагш нэг алхаад хөшчихөв. Саша өөрийг нь горьдох, царайчлах хослуулан харж буй, үхлээс өөр замгүй болсон эдгээр хүмүүсийн царайг ажиглав. Машин руу очно гэдэг бол амьд үлдэх цорын ганц боломж. Ямар ч буруу байхгүй, командлалын алдаа, бүтэлгүйтлийн төлөө амь насаа өгч байгаа улс. Тэднийг “байлдан тандах” ажиллагаанд задгай газраар урагш явуулахад дайсан тэдэн рүү галлаж бүгдийг нь устгана, тэр хооронд манайхан галын цэгийг нь мэдэж авч устгана, тэгсний дараа давшилтад орно. Энэ дайны нэг харгис арга ийм юм.

Торгуулийнхны хэнд нь ч жолоочийн үнэмлэх алга: “баривчлахдаа хурааж авсан”, “гээчихсэн”, “хамтралд тракторчин байхад ачааны машины жолоон дээр суух хэрэг гардаг байсан”. Хоёр пулуу хөөж ирлээ. Торгуулийн нөхрийг жолооны ард суулгаад, дэслэгч хажууд нь сууж, машин яаж барьдгийг нь шалгав. Бүтэн сумангаас арван долоон хүн сонгож авсан, тэд нар нь эрхбиш машиныг байрнаас нь хөдөлгөж, нэг тойрог явахчаан болсон хүмүүс.

Гурван цаг гэхэд ажлаа дуусгав. Энэ бол долдугаар сарын дөрөвний өдөр. Саша шилж авсан жолооч нараа авто сумангийн төлөөлөгчид хүлээлгэж өгөөд, 13 дугаар армийн инженерийн цэргийн штаб руу явав. Ахмад Иванова дахиад л цэргийн байрлалаар яваа гэнэ, чухам хаана гэдгийг нь хэлж өгсөнгүй, хувийн хэргээр яваа танихгүй офицерт тэр тухай мэдэх шаардлага байхгүй гэж байх нь.

– Би ч азгүй хүн юмаа хэмээн Саша инээмсэглээд, – Москвад хөршүүд байсан юм гэв. Штабынхныг зөөлөрч магадгүй гэж горьдсондоо тэр. “Цэргийн байрлал” гэдэг нь дивиз, арми зургаан дивизтэй юм чинь, дугаарыг нь хэлчихвэл Варяг олоход амар. Тэгсэн чинь зөөлрөх янз алга. Саша хамгийн ойрын дивиз рүү явав, тэр дивизийг Максим командалж байгаа. Варя ч тэнд байж байж магадгүй, байхгүй бол хайж олохыг инженертээ даалгана, тэдний уулзалт хэдэн цагаар л хойшлоно биз, тэр яахав, гол нь түүнтэй уулзах!

Өдрийн халуун буурлаа. Санаанд оромгүй намуухан орой, онгоц ч алга, буун дуу ч алга, ерөөсөө дайн ч байхгүй юм шиг.

Шалган нэвтрүүлэх цэгийн зохицуулагч бүсгүй шар дарцгаар дохиж машин зогсоогоод, бичиг баримт шаардав.

– Түүнгүй бол болохгүй юү? гэж Саша тоглож асуув.

– Болохгүй, журамтай байх хэрэгтэй.

Аятайхан бүсгүй, даавуу малгайтай, цэрэг цамцтай, хөх банзалтай, дажгүй савхин гуталтай.

Цаашаа явлаа. Хөндийд гүвээ толгод, нэгэн төгөл харагдана. Тэр төглийг хүртэл танк хориглох мушгиралдсан шуудуу байна. Тэнгэрт гэрэлтүүлэх пуужин гялсхийлээ. Хоёр ногоон, нэг улаан шар, нэг цагаан, дахиад хоёр ногоон, энэ бол германы пуужин, тэргүүн шугам ойрхон буйн шинж.

Максимын туслах Сашаг оруулсангүй.

– Генерал зөвөлгөөн хийж байна, та хүлээзнэх болох нь.

Утас байн байн дуугарч, туслах юм тэмдэглэж авах юм уу, заримдаа Максимтай холбож өгч байв. Хажуугийн өрөөнөөс холбоочны: “Би Сокол, би Сокол, сонсгол ямар байна? Сонсож байна...” гэх нэгэн хэмийн дуу сонсдоно.

Тэгж тэгж хаалга нээгдэн, Максимын тэндээс гурван хурандаа гарч ирэв: штабын дарга, арын алба эрхэлсэн орлогч, гуравдахь нь улс төрийн орлогч бололтой. Тэдний санааширсан царайг хараад нэг юм болж гэж Саша ойлгов.

Максим үүдэндээ гарч ирээд,

– Хошууч, ор! гэж Саша руу хайнгадуухан дохив.

Ширээн дээр зураг дэлгээстэй харагдана. Максим суугаад, Сашаг суу гэж урив.

– Миний чамд хэлэх гэж байгаа юм бол задруулах ёсгүй зүйл. Арван тавдугаар дивизийн зурваст дэслэгч Милешкиний удирдсан тагнуулчид Фермелло гэдэг германы нэг сапёрыг олзолсон байна. Тэр сапёр довтолгоо долдугаар сарын тавны өглөөний гурван цагт, өөрөөр хэлбэл, өнөө шөнө эхэлнэ гэж мэдүүлсэн байна. Би үүнийг үнэн гэж бодож байна. Тийм учраас чи эндхийнхээ ажил явдлыг дуусгаад, штаб руугаа буц.

– Би энд ердөө ганцхан ажлаар явна: би Варятай уулзах ёстой. түүнийг дивизээр яваа гэж надад хэлсэн, тэгээд танайд байж магадгүй гэж бодлоо?

Максим дуугарахгүй азнав.

– Варя өчигдөр энд ирсэн, тэгээд Арван тавдугаар дивиз рүү яваад өгсөн, тэнд хөршүүдтэйгээ зөрчилдсөн нэг юм гарсан гэнэ лээ, чухам тэндээс тэр сапёрийг олзолж. Утасдана гэчихээд утасдсангүй, одоо бол илүү чухал яриа байна гээд утсаар яриулахгүй ч байж магадгүй нөхцөл байдал үүсээд байна. Би манай инженерт Варя хаа байгааг өөрийнхөө шугамаар олж мэдэхийг даалгасан юм. Гэтэл тэр: “Зуун гучин хоёрдугаар дивизийн дэвсгэр рүү явсан” гэж хариулсан. Тэр дивиз бол манайх биш, Далдугаар армийнх гэдгийг чи мэднэ гээд Максим утас руу дохиж, – Би цагийн өмнө Арван тавдугаар дивизийн дарга Жанжгаватай ярьж Варяг сураглалаа. Тиймэрхүү асуулт тавихад нэг их тохиромжтой мөч биш гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Тэгсэн ч гэсэн би асуусан. Тэр бас: дивизийн инженертэй хөрш дивиз рүү явсан гэж хариулсан гэв.

– Хаахна байж болохыг чи надад үзүүлэхгүй юү?

Максим зураг дээр заав.

– Энэ Красная Заря — Красный Уголок гэснийг харж байна уу? Энд манай хоёр армийн уулзвар байгаа, энд л инженерүүд учраа ололцож байгаа, үүгээр л германууд цохилт хийнэ гэж бодож байна. Ольховаткийн чиглэлээр хөдлөх бололтой байна. Чи чинь тийшээ явах гээ юү?

– Тэгэлгүй яахав. Ийм нөхцөлд заавал явалгүй болохгүй.

Максим хөмсөг зангидав:

– Хаашаа явахаа мэдэх хэрэгтэй. Фронт чинь том шүү дээ, хаана байгаа гэж чи түүнийг эрэх юм? Германууд довглоод эхлэх юм бол чи өөрөө төөрчихнө. Варягийн хаана байгааг мэдэх хэрэгтэй. Чи манай инженер дээр оч, тэр чамд туслана, түүнд эрхбиш ямар нэгэн холбоо байгаа.

– Би танайд томилолтоо бөглүүлчихвэл болох уу?

– Манай туслах яг ёсоор нь болгоод өгнө.

Дивизийн инженер Велижанов гэж гуч эргэм насны, өндөр сайхан хошууч Сашаг найр тавин угтаж, харах царайнаасаа тус болох гээд байгаа нь илэрхий ч, харамсалтай нь, шинэ юм юу ч хэлж чадсангүй, Максимаас дуулсныг нь л хэлэв.

– Өөрийнхөө штабт эргээд ирсэн байж магадгүй. Утасдая.

Утсаа авч, зохих дугаарыг хэлэв.

– Хоёулаа хүлээзнэе, одоо холбоод өгнө.

тэрээр Саша руу малилзан харж байв. Энэ хүн өөрийнхөө зангаар ийм найрсаг, нөхөрсөг юм уу, эсвэл дивизийнх нь дарга хэлсэн учраас ийм байгаа юм уу гэдгийн учрыг Саша хувьдаа олсонгүй. Варя даргынх нь хамаатан гэдгийг мэдэж байгаа, бас нөхөр нь хэн гэдгийг ч мэдэж байгаа. Гэтэл хошууч Панкратов тэдэнтэй ямар холбоотойг санаа нь зовоод асуухгүй байна, генерал тушаасан юм чинь асуулт тавиад байх биш, тушаалыг л биелүүлэх ёстой. Велижановын хамгаалалтын байр давчуухан, чийгтэй, газар ханхалж байгаад Саша гайхжээ. Инженерүүд өөрсөддөө голдуу аятайхан хамгаалах байр барьдаг билээ.

Саша иймэрхүү дэл сул бодлоор сэтгэлийн хөдөлгөөнөө дарзнав. Варя тэргүүн шугам дээр байж байдаг. Германууд довглоод эхэлвэл яаж тэндээс гарах болж байна? Хэн ч түүнийг тоохгүй. Юу ч болдог байсан, Варя дээр яаж ийгээд очих хэрэгтэй.

– Байна уу, байна уу... А-хаан... Таныг ойлголоо, ойлгомжтой, баярлалаа.

Велижанов утсаа тавиад санаа алдав.

– Варвара Сергеевна томилолтоос хараахан эргэж ирээгүй гэнэ. Өглөө тодорхой болно, хүлээх хэрэгтэй гэж би бодож байна.

Саша түүний өмнө зургаа гаргаж дэлгээд,

– Красная Заря, Красный Уголок хүрэх замыг та зааж өгөөч гэв.

– Янз янзаар хүрч болно.

Велижанов зураг дээр хэдэн зам зурж, суурин газрыг тэмдэглээд харандаагаа тавьж Саша руу нухацтай харав.

– Хошууч аа, би танд нэг зүйл урьдчилан анхааруулах ёстой. Та Красная Заря, Красный Уголок хоёроос Варвара Сергеевнаг олохгүй. Цэргүүд байлдааны байршлаа эзэлчихсэн, тулалдаанд холбогдолгүй бүх хүнийг зайлуулсан, Варвара Сергеевнаг хааш нь зайлуулсныг бид мэдэхгүй. түүнийг одоо фронтоос хайна гэдэг бол өдөр тэнгэрээс од хайсантай адил юм болно. Тэгээд ч та шөнө хаа ч хүрч чадахгүй, замдаа төөрчихнө, гэрлээ асаавал герман таныг буудаад эхэлнэ, ер нь таныг цэргийн байршил руу хэн ч оруулахгүй. Өглөө болтол хүлээх хэрэгтэй, байдал тодроно, үгүйдээн зам ил болно.

Саша Велижановын тэндээс гарав. Бяцхан төгөлд нуугдсан штаб нам гүм болжээ. Тэнгэрт од түгчихсэн, дулаахан байна. Германууд довтолгоо эхлэх гэж байгаа бол тэдний хувьд тохиромжтой шөнө байна.

– Хаашаа явахав? гэж Николай тавьдаг асуултаа тавив.

– За тэгэхээр, Николай, би Арван тавдугаар дивиз орох хэрэгтэй боллоо. Гэтэл тэргүүн шугаман дээр түгшүүртэй байгаа. Энэ бол миний хувийн хэрэг учраас чамайг эрсдүүлэх эрх байхгүй, би ганцаараа явна.

Николай жолоон дээрээ зөрүүлсэн гар руугаа тонгойж, Саша руу эргээд,

– Энэ тухай яриа ч байх ёсгүй. Та хаашаа, би тийшээ гэв.

– За, сайхан мэдээрэй, би чамд урьдчилж хэллээ шүү. Одоо хоёулаа жаахан дугхийчихье.

Николай урд суудал дээрээ, Саша арынх дээрээ суран бүсээ хоёр нүхээр сулруулж, гар буугаа өмнөө аваад, хажуулдан хэвтээд унтав.

Гурван цагт тэднийг их бууны нүргэлсэн дуу сэрээлээ. Николай тэр хоёр бие биенийхээ үгийг дуулахааргүй буун дуу пижигнэж байна.

Төв фронтын цэрэг их буугаар маш хүчтэй сөрөг гал нээж германуудын довтолгоог хоёр цаг хагас тогтоов.

Германууд дайралтаа өглөөний 5 цаг 30 минутад эхэлжээ. Урт голтой буу нь шунахайрах мэт зүтгэсэн, зузаан духтай “бар” гэдэг хүчирхэг намхан танкнууд их буу, нисэх онгоцоор дэмжүүлэн, шаантаг маягаар хошууран довтолж, тэр дунд нь явж байгаа дунд гарын танк, хуягт тээвэрлэгчид хааяа зогсоход явган цэрэг асгарах мэт бууж дайралтад орцгооно. Германы бөмбөгдөгч онгоц 50-100-гаараа бүлэглэсэн нислэг үйлдэж байв. Сум, бөмбөг, мина тэсрэн хамаг юмыг дөжрөөж, хүмүүс гагцхүү дохио зангаагаар харилцана. Тэнгэр өөд бөөн гал, утаа олгойдоно.

Өглөөний гурван цагт их бууны сөрөг галлалт эхэлхэд хошууч Велижанов бусад офицерийн хамт Максимын хамгаалалтын байр руу гүйх зуураа Сашад,

– Одоо байдлыг тодруулна гэж хэлж амжив.

Зөндөөн удаан хүлээж таарав. Николай жолоон дээрээ гараа тавин зүүрмэглэнэ. Саша ийш тийш холхиж, заримдаа машиныхаа арын суудалд хаалгаа онгорхой жаахан суузана. Тулалдааны чимээ тов тодхон сонсдож, түймрийн туяа газар тэнгэрийн савслагат улаарна.

Максим өглөөний долоон цагт хамгаалалтынхаа байрнаас гарч ирж, тэр даруйд нь модон дотроос давхин ирсэн “виллис”-дээ суугаад явчихав. Бараг бүх офицер таран одоцгоов. Велижанов гарч ирээд, Сашаг дуудан оруулж, зургаа өмнө нь дэлгээд,

– За, хошууч, байдал ямар байна гээч. Манай армийн хэсэг дээр дайсан Арван тавдугаар дивизийн байрлалаар дайрч ороод, Ольховаткийн чиглэлээр урагшилж байна, Арван тавдугаар дивизийн штабыг нүүлгэн шилжүүлсэн. Далдугаар армийн хэсгээр дайсан Красная Заря, Красный Уголок руу довтолж байна, Зуун гучин хоёрдугаар дивизийн штабыг бас нүүлгэсэн. Варвара Сергеевна хаана байгааг бид мэдэхгүй байна. Хэрэв дайсан хоёрдугаар зурвас хүртэл дайрах юм бол манай дивиз бүр өнөөдөртөө тулалдаанд орно. Генерал удирдлагынхаа цэг рүү яваад өгсөн гээд Сашаг харав.

– Та надад юу гэж зөвлөмөөр байна?

– Хэрэв та одоо түүнийг хайхаар явах юм бол олохгүй, бас холбоогүй болно, таныг утас руу юм уу, радио холбоо руу хэн ч ойртуулахгүй. Таныг одоохондоо хаашаа ч явахгүй байхыг зөвлөх байна, ямар ч гэсэн эндээс байдал арай илүү мэдэгдэнэ, эрхибиш муу ч, сайн ч холбоо байна. Байдал хаашаа эргэхийг харцгаая.

Зарлага цэрэг орж ирэв.

– Нөхөр хошууч, штабын дарга яаралтай дуудаж байна.

– Ямар нэг юм мэдээд ирэх ч юм бил үү гээд Велижанов явлаа.

Саша машиныхаа дэргэд хойш урагш холхив. Хугацаа алдаж байна, цаг алдаж байна, гэвч Варяг хаана байгааг мэдэхгүй байж, байлдааны замбараагүй байдалд дунд сохроор явах юм

бол улам ч их цаг алдана. Хүлээхээс өөр яахав, Велижанов юухан ч болохноо хэлж, ямар нэгэн сэжүүр гарч ирэх ч юм бил үү? Тэгээд Велижановын гарч ирэхийг хүлээн, штабын даргын хамгаалалтын байр руу тэсч ядан харж байв.

Юм уумаар санагдаад, Николайгаас ус гуйв. Николай хашир хүн учраас нэг нь устай, нөгөө нь бензинтэй хоёр хавчигтай. Саша сэнжтэй аягаараа дүүрэн ус хийж авав.

Тэгж тэгж Велижанов гарч ирээд, газар байр руу Сашаг дагуулан орж бас зургаа дэлгэв.

Дайсан Ольховаткийн зүг урагшилсаар байна. Арван тавдугаар дивиз хоёрдугаар зурвас руу ухарсан. Зуун гучин хоёрдугаар дивиз Дегтяный — Рудово гэсэн шугам руу ухарч байгаа. Арван тавдугаар дивизийн инженер Кочин одоогоор алга, гэхдээ түүнийг ингэсхийгээд ирнэ гэж хүлээцгээж байна. Энэ бол найдлага төрүүлж байна, Варвара Сергеевна түүнтэй хамт байж магадгүй.

Велижановын нэрлэсэн тосгоныг Саша өөрийнхөө зураг дээр тэмдэглэж, тэр хавийн хээрийн болон ойн бүх замыг Велижановын том зураг дээрээс буулгаж авав.

– Та ямартай ч явах гэж байна уу? гэж Велижанов асуув.

– Тийм.

– Байлдааны үед фронтоор явах чинь...

– Харин тийм... тус болсонд баярлалаа гээд Саша гараа өгөв.

– Амжилт хүсье, за бас нэг юм гээд тэрээр зураг руугаа зааж, – Энэ нэг төглийг харж байна уу? Арван тавдугаар дивизийн штаб нүүсэн бол командын нөөц цэг нь энэ, ийшээ шилжинэ. Бас хошууч Кочин ирсэн бол энэ төгөл рүү ирнэ. Мэдээж, энэ бол болзол төдий зүйл, гэхдээ танд эрхбиш нэг баримжаа болох байх. Варвара Сергеевнатай уулзвал мэнд уламжлаарай гэснээ том цэнхэр нүдээ дүрлийлгэн Саша руу харж, – Өршөөгөөрэй, хошууч, даруу биш юм асууя: тэр таны хамаатан уу? гэв.

– Дүү гэж Саша хариулав.

Хоёр талын их буу байдаг хүчээрээ буудалцаж, “бар”-нууд галлан урагшилж, “юнкерс”-нүүд хамгаалалтын хоёрдугаар зурвасаар бөмбөгдөж эхлэв. Зөвлөлтийн сөнөөгч онгоц, танк ч байлдаанд орлоо. Сашаг шалган нэвтрэх цэг болгон дээр зогсоож, бичиг баримтыг нь үзэж, хаашаа явж байгааг нь шалгаан зөндөөн удаан саатуулж байв.

тэрээр тэг тэгсээр Велижановын зааж өгсөн төглийг хүрэв. Тун сая нүүн ирж байгаа штаб энд хичнээхэн ч удах юм билээ, бүр өнөөдөр ч цааш ухрах хэрэг гарах юм сан уу, эмхэрч цэгцэрсэн юм алга, Сашагаас бичиг баримт шаардах хүн ч алга. Хошууч Кочиныг сурагласанд, хамгаалалтын байрны хавьд сууж байгаа дунд хэрийн насны түнтгэр хошуучийг зааж өгөв. Нэг гар нь боолттой, нөгөө гараараа дэргэдээ зогсож байгаа дэслэгчид нэг юм тайлбарлан зураг дээгүүр зааж байв. Саша түүн рүү очиж, өөрийгөө танилцуулаад, хошууч

Кочин гэж та биш биз гэж асуув.

– Мөн, би Кочин байна.

түүний сормуус, хөмсөг энэ тэр нь хуйхлагдчихсан, хөдлөх төдийдөө ярвайж байхыг харвал нүүр, гар нь их хөндүүрлэж байгаа бололтой.

– Намайг тань руу хошууч Велижанов явуулсан юм. Би инженер-ахмад Варвара Сергеевна Ивановаг хайж явна гэж Саша хэлэв.

– Варвара Сергеевна шархадсан, сумны хэлтэрхий цээжнийх нь баруун хэсэгт туссан, уушиг нь өртсөн байх, цус их алдсан. Би Рудовод, батальоны эмнэлгийн цэг дээр хүргэж дөнгөсөн, бага эмч түүний биеийн байдлыг хүнд гэж байна лээ, гэхдээ өнөөдөр хорооны эмнэлэг рүү хүргүүлнэ гэж амласан. Амийг нь аварч магадгүй.

Саша зогсож байсан чигээрээ хөшчихөв. Варятай уулзахаасаа өнгөрчээ!

– Цэргийн эмнэлэгт маш түргэн аваачих хэрэгтэй байсан юм, гэтэл юугаар аваачих вэ дээ? Би Рудовоос ийшээ явган ирлээ гэж Кочин учирлав.

Сормуусгүй зовхиороо анивчих нь харахад өрөвдмөөр гэж.

– Варвара Сергеевна тас зөрүүдэлж, дарга нартай ам мурийгаад, дивиз рүү явахаас татгалзаж, хороон дээр хоносон чинь шөнө хамаг юм эхэлдэг байгаа даа, минийн дэлбэрэлтэнд өртсөн, хажууханд нь сувилагч байсан нь яамай, халыг мөлт ч болохноо боолт хийсэн.

Саша зургаа гаргаж, Рудово хүрэх замыг Кочины зурагтай тулгаж шалгав. Ил задгай газар, гэхдээ энд тэнд төгөл, армаг тармаг ойтой аж.

Саша Рудово тосгонд орой болж байхад ирэв. Тосгоны нэг захад байлдаан үргэлжилж, модон байшингууд шатан, их бууны сум тэсрэн, дээрээс хаясан бөмбөг шуугин унаж, мина дэлбэрч байхад, нөгөө Сашагийн ирсэн захад хоёр асрагч шархтангуудыг том хөвөнтэй хөнжил дээр дамжлан зөөж, зарим нь винтовоо тулан хазганасаар ирэхэд ахимаг насны бага эмч, сувилагч бүсгүй хоёр тэднийг бушуухан боож өгөөд морин тэргэн дээр суулгахыг нь суулгаж, хэвтүүлэхийг нь хэвтүүлж байлаа.

Николай машинаа модны дор тавив. Саша бага эмч дээр очиж, Иванова гэдэг инженер-ахмад энд байсан эсэхийг асуув.

– Нэр ус бичихгүй байгаа, тийм зав байхгүй гэж бага эмч нэг шархтанг боох зуур хариулснаа,
– Харин ганц офицер хүүхэн байгаа гээд захын модон байшин руу дохиж, – Тэнд хэвтэж байгаа, боолт хийсэн гэв.

Саша тэр байшинд орлоо. Варя сүрэл дэвссэн шалан дээр цэрэг цамц нь урагдчихсан, мөр, цээж нь боолттой, нүд нь аниатай хэвтэж байна. Саша сөхрөн суугаад гарыг нь атгасанд гар нь хүйтэн байна... Нүүрийг нь ширтэн ажиглаад, өвдсөндөө ярвайж хярвайсан царайны цаанаас, цонхийж цайсан үхмэл царайны цаанаас, өнгөрөн одсон арван жилийн цаанаас

хуучны Варяг, памбагардуу уруултай, дух руугаа унжсан үсийг үлээж байгаа охиныг олж харав... тэрээр сөхөрсөн чигээрээ, гарыг нь атган, амьсгалж байгаа эсэхийг нь ойлгож ядахдаа нүүр рүү цөхрөн харж, нүдээ нээгээсэй билээ хэмээн хувь заяандаа залбиран гуйлаа.

Тэгтэл Варя нүдээ нээж, сүүмгэр харцаар Сашаг хараад, уруул нь инээмсэглэж цөхөн өмөлзөв:

– Чи ирээ юү, Саша...

Тэгээд дахиад нүдээ анилаа.

37

Байлдаан ойртсоор. Их бууны сум, мина гудамжны голоор тэсэрч эхлэв. Бага эмч боолтоо дуусгаад шархтангуудыг сүүлчийн тэргэнд яаравчлан суулгаж, явахтайгаа байгаа заримыг нь тэрэгний гуянаас бариад яв гэж тушаагаад, дэлбэгчид: “Хөдлөөрэй!” гэж хашгарав. Цүнхэндээ самбай, хөвөн, йодоо хийх зуур Сашад,

– Би хүнд шархтай нэг эмэгтэй офицер байна, машин ирүүл, шууд эмнэлгийн батальонд эсвэл бүр цэргийн эмнэлэгт аваачих хэрэгтэй, энд ирэхдээ цус алдчихаад ирсэн, ачаалал даахгүй гэж хороо руу хэлсэн. Машин ирүүлсэнгүй гээд түнтийтэл чихсэн цүнхээ арайхийн хаав. – Одоо яадаг билээ? Та эмнэлгийн батальон юм уу эсвэл цэргийн эмнэлэг хүргээд өгчихгүй юм уу? гэж хэлэв.

– Эмнэлгийн батальон хаана байна, цэргийн эмнэлэг хаана байна?

– Одоо хаана байгааг хэн мэдэх вэ? Бид ухарч байна, тэгэхээр тэд ч ухарч байгаа. Та олно. Гремячье-д, Фатеж-эд... Замаасаа сураглана биз. Машиндаа нуруугаар нь хэвтүүлээд, дэр хийж өгөөрэй, тэгээд замаа шилээд аятайхан яваарай.

Бага эмч цүнхээ мөрөн дээгүүрээ хаяад, тэрэгний араас гүйх шахан алхлав.

Саша, Николай хоёр Варяг хөнжил дээр дамжлан машиндаа хүргэж, хойд суудал дээрээ хэвтүүлээд, хуйлсан шинелиэр дэр хийж өгөв. Саша шалан дээр суугаад хөлийг нь дэмнэж явав. Варя нүдээ нээхгүй, заримдаа зовхи нь анивчих шиг, нүүр нь татваганах шиг болно. Тэр хоёрыг өргөж, хэвтүүлж байх хооронд шарх нь хөндүүрлээд тэгсэн үү, ёолох шиг санагдсан, чухам тэгсэн үү, үгүй юү гэдгийг буун дуу, бөмбөгний дэлбэрэлтээс болоод ялгаж ойлгох арга байсангүй. Эхлээд Гремячье рүү явав, эмнэлгийн батальон тэндээс явчихсан байвал Фатеж орцгооно. Зурган дээр Рудовогоос зургаан километрийн алдад ой тэмдэглэсэн байна, үгүйдээн бага ч гэсэн халхавч юм чинь, тэнд зогсож, урд суудлынхаа түшлэгийг авч, Варяг арай эвтэйхэн хэвтүүлж болно. Сийчих бөмбөг дэлбэрч хар шороо олгойдуулан босгож, тэсэрдэг сум яг хөрсөн дээр дүрэлзэн тэсэрч, замыг хаа сайгүй онгичиж дэлбэлж хаяжээ. Саша донсолгооны цохилтыг багасгах санаатай Варяг дэмнэн яваа бөгөөд заримдаа нэгэнт үхсэн бие авч яваа юм шиг санагдан, дэмий л нүүр рүү нь харж, амьсгааг нь чагнана. Варя одоо хэр амьд байгаа ч, үхнэ гэдгийг нь Саша мэдэж байв.

Ойн дагуух зам тэгтлээ онгилогдоогүй ч, тэдний ард байлдааны чимээ намдах нь битгий хэл, дэлбэрэлт, тэсрэлт, буун дуу, онгоцны урхираан бүгд нийлэн тасралтгүй нүргэлнэ.

– Таван километр хэртэй яваад зогсоё...

Саша үгээ гүйцээж хэлж амжсангүй... Яг хажууханд нь панхийж, тархинд хадтал шунгинаад явчихлаа, их бууны үрэлтэй сум л ингэж тэсэрдэг, дараа нь шил хагарах сонсдоод, машин нь зогсчихов... Николай гарч машинаа шалгаж хараад, хамрынхаа нээлхийг сөхөв.

– Хамаг юм өм цөм явчихаж.

Нүүрний болон хажуугийн шилийг хагалсан сум Николайд туссангүй.

Саша машинаас гарч орчныг харвал тэнгэрт түймрийн туяа татаж, зүүн талаар тэртээ хаяанаас хар хайрцаг шиг юм мөлхөн бүхий нь танк ирж яваа хэрэг!

– Алив түргэлье! гэж Саша бачимдав.

Варяг хөнжлөөр дамжлан мод руу оруулаад, эргэж ирж шинель, автомат, үүргэвч, устай хавчгаа авав. Ямар ажил гарахыг мэдэж байгаа учраас хүрз, сүхээ бас авав.

Варяг ой дундуур зуугаад метр авч явав. Модны орой суманд хуга хуга цохиулсан, эргэн тойрон даавуу шуувуу, дарсны шил, нөөшний лааз, янжуурын хайрцаг, шарласан сонины тасархай хөглөрөөд, хавар энд германууд байсан нь илт.

Варяг цааш нь ойн гүн рүү аваачиж, үндэс нь сэргийн булгарсан нэг том дархины хавьд зогсоцгоов. Хавийнх нь газар тэгшхэн, шинэхэн ногоотой, цэвэрхэн аж. Варяг буулгаж, хуйлсан шинелиэ дахиад дэрлүүлэв. Саша амьсгааг нь чагнаж үзвэл амьсгалж байх шиг, боолтыг нь үзвэл нөгөө л хатсан цус нь хэвээр, шинэ цус алга. Хавчигнаасаа ус аягалаад, Николай Варягийн толгойг яльгүй өндийлгөхөд, нүүр нь дахиад татвалзах шиг болов. Саша түүний ам руу хэдэн дусал ус хийсэн боловч залгисангүй, завьжинд нь хураагдчихлаа.

– Хэрэггүй юм уу, усанд цацаж мэднэ гэж Николай өгүүлэв.

мань хоёр ногоон дээр хэвтээнэв. Нар нэгэнт жаргах тийш хандаж, газар дээр сүүдэр хүүшлэн байвч өдөр шиг хуурай байна. Николай гал түлж, бяцхан сэнжтэй тогоондоо шар будааны бэлдмэл чанасныг идэцгээв. Агшаасан будааны үнэр, чад чадхийн ноцож байгаа гишүү Сашад нэгэнтээ түүдгийн дэргэд сууж байсныг нь санагдуулав. Хорихын дамжин өнгөрүүлэхэд цуг байсан нөхөд нь одоо байхгүй. Карцевийг тэд Богучанд оршуулсан, бууж өгдөггүй Володя Квачазе лагерьт алуулсан нь мэдээж, Соловейчик тайгад үхсэн. Бүгд яваад өгсөн, мань хүн л ганцаараа саатан хоцорчээ.

– Энэ чинь таны хэн юм бэ, нөхөр хошууч? гэж Николай асуув.

Саша чимээгүй хэсэг байзнав. Велижановыг ингэж асуухад дүү гэж хариулсан, цаадах нь Варя хэний авгай гэдгийг мэдэх учраас өөрөөр хариулах арга байгаагүй.

– Хоёр биендээ хайртай байсан юм, тэгээд арван жилийн дараа уулзаж байгаа нь энэ. Яаж уулзаж байгааг чи харж байна.

Ойд харанхуй болов.

– Та жаахан дугхий, би суузнаж байя гэж Николай санал болгов.

– Үгүй, харин чи унтзана, дараа нь ээлжлэе, би чамайг сэрээнэ. Шинель ав!

– Та өөрөө нөмөр, шөнө сэрүүхэн болно шүү.

– Тэр яахав, аваад хэвт! Санаа зовох хэрэггүй, би заяа нь хөлдчихгүй, үүр цайхаар цаашаа хөдөлнө.

Николай шинелийн арын түдүүлийн товчийг тайлж нөмрөөд унтлаа.

Саша Варягийн дээрээс тонгойж чагнавал амьсгалж байна, гараас барьж судсыг нь удаан хайсны эцэст аяархан лугшиж байгаа нь мэдэгдэх шиг ч, эсвэл өөрийнх нь хурууны судас цохилж байгаа нь тэр юм уу.

тэрээр Николайд: “Үүр цайхаар цаашаа хөдөлнө” гэж хэлсэн, гэхдээ хаашаа ч явахгүйгээ өөрөө мэдэж байгаа, үхлээс зайлах газаргүй болсон. Ийм бодлоос айдас төрөхгүй байна. Цааш амьдрах хүсэл алга, тэр амьдралд Варя байхгүй юм чинь. түүний бүх өнгөрсөн үе, зовлон зүдгүүр, хэсмэл амьдрал бүгд улирч алга болсон, өөрт нь ганц Варя л үлдээд байна. Саша түүний гараас барьж, нүүр рүү нь харж байгаад аяархан “Варя” гэж дуудав. Сонсох ч юм бил үү? Сонссонгүй. Дуугарахгүй байна. Моддын цаанаас сар эс харагдавч, гэрэл нь навчсыг нэвглэн, Варягийн нүүрэн дээр зуралзахад, уруул нь хөдлөн амандаа ярьж байх шиг болно. Саша дахин тонгойж: “Варя” гэв. Варя хариу дуугарсангүй. Бутыркийн шоронд байхдаа яагаад түүнийг уулзая гэж дуудуулаагүй, яагаад түүнийг сүйт бүсгүйгээ гэж нэрлээгүй билээ? “Чиний одоо юу хийж байгааг би ёстой мэдмээр байна...” Өөрөө яагаад ийм үг олоогүй юм бэ? Калининаас ямар муухай ярьсан гээч. “Чи надад өөр юу ч хэлмээргүй байна уу, Саша?” Хэрэв тэгэхэд хайртай гэдгээ хэлсэн бол, хүлээж байгаа гэдгээ хэлсэн бол, бүх юм өөрөөр эргэх байсан байж магадгүй, тэгсэн бол одоо ингээд үхэж байхгүй байсан байх. Тэгж хэлээгүй.

Хэдий тийм ч... Амьдралынхаа сүүлчийн үгийг өөрт нь хэлсэн. “Чи ирээ юү, Саша...” Өөрийг нь хүлээж байж. “Чи ирээ юү, Саша...” Ирсээн, одоо хэзээ ч явахгүй.

Варягийн царай гэнэт бараантаад явчихсан нь сар үүлний цаагуур орсон юм байж. Үхсэн юм шиг санагдаад Саша цээж рүү нь тонгойход зүрх нь цохилж байгаа юм шиг. Дахиад дуудсан боловч бас л дуугарсангүй.

Саша хэд алхсанаа унасан дархийг налав. Оройн сэрүүний оронд бүлээхэн хуурай амьсгал оржээ. Ээж нь одоо өөрийнх нь тухай бодож байгаа байх. Ээжийгээ л өрөвдөх юм.

Нэг хүн шүргэх шиг болоход сэхээ авч харвал Николай зогсож байв.

– Нөхөр хошууч... гээд Николай Варягийн зүг дохив.

Саша Варя руу очиж, хоёр нүдийг нь ээлжлэн нээж үзэв. Варя үхсэн байв.

– Дуусчээ, нөхөр хошууч гэж Николай өгүүлэв.

Саша Варягийн зовхийг буулгаад, халааснаас нь бичиг сэлт болох үнэмлэх, томилолтын ажлын заавар, бяцхан харандаатай жижигхэн тэмдэглэлийн дэвтэр энэ тэрийг гаргаж өөрийнхөө халаасанд хийгээд, Варягийн хоёр гарыг цээжин дээр нь зөрүүлж тавиад бослоо.

Үүр хэдийнэ цайж, их буу нижигнэн, бөмбөг дэлбэрч эхлэх нь тэр.

Саша орчноо харж, арай зайчилж болох газар сонгож олоод, хүрзээ авч булшны газрыг дөрвөлжлөн гишгэж зурвас гаргаад, Николайд,

– Сүхээ аваад модны үндэснүүдийг тас тас цохиод бай гэв.

Николай үндсийг тас цохилон, Саша хүрзээр гишгэн ухав. Тийнхүү нэг үү, хоёр уу, цаг ажиллаад тохой хэртэй ухсан байх, нүхэн дотор байсан Николай гэнэт цэхэрч, чих тавьснаа, Сашаг ханцуйнаас нь чангаан унасан модны араар оруулаад, нэг автоматаа авч, нөгөөг нь Сашад өгөв. Нэг хүн модноос мод руу гэтэн гүйсээр тэдэн рүү дөхөж айсуй.

– Хэн явж байна? гэж Саша хашгарав.

– Та нар хэн юм?

– Зөвлөлтийнх.

Модны цаанаас винтовгой хоёр цэрэг гарч ирэв. Өөрснийх нь гэдгийг мэдмэгц, нэг нь хуруугаа амандаа хийж байгаад шүгэлдсэнд, цаанаас нь дахиад хэдэн цэрэг гарч, бараг нэг салаа байх, тэдэнтэй хамт онгомол цэрэг цамцтай, шороотой нүүрээр нь хөлс гоожсон залуухан дэслэгч ирэв.

– Хаанаас хаашаа явж байна? гэж Саша асуув.

Дэслэгч цэргүүд рүүгээ дохиж,

– Явцгаа, би араас чинь очно гэв.

Тэгээд цээжин дээрээ гар нь зөрүүлээстэй хэвгэж байгаа Варя, булшны нүх хоёрыг ээлжлэн харснаа,

– Бүслэлтээс гараад, товлосон цэг рүүгээ явж байна гэв.

– Аль ангийнх юм?

– Арван тавдугаар дивиз. Зургаан зуун далан зургадугаар хороо, дарга нь хурандаа

Онуприенко.

– Николай, дэслэгчтэй цуг яв! гэж Саша тушаав.

– Таньгүй бол би явахгүй, нөхөр хошууч гэж Николай зөрөв.

– Тушаал биелүүл! гэж Саша дуугаа өндөрсгөв.

– Нөхөр хошууч! гэж Николай цухалдав.

– Тушаал биелүүл! гэж Саша давтан хэлэв.

– Нөхөр хошууч, та ч үлдэж болохгүй, бидний араас германууд явж байгаа, энэ ойг самнаж таарна гэж дэслэгч хэлэв.

– Ойлгомжтой! Николай, намайг Рудово тосгонд үлдсэн гэж илтгээрэй.

– Рудово сууринг дайсан өчигдөр орой яг арван есөн цагт эзэлж авсан гэж дэслэгч өгүүлэв.

– Тэгвэл, Рудовогийн ойролцоо ойд үлдсэн гээрэй.

Николай Сашаг царайчлан харав.

– Бушуухан юмаа ав, дэслэгчийг битгий саатуул гэж Саша тушаав.

Николай шинель, автоматаа авч, үүргэвчээ өргөв.

– Гранатаа үлдээ.

Николай гурван гранат гаргаж унасан модны хажууд тавиад, үүргэвчээ мөрөн дээгүүрээ хаяв.

– Дэслэгч, таны овог хэн билээ? гэж Саша асуув.

– Никишев хэмээн дэслэгч салаагаа гүйцэх гэсэндээ яаран өгүүлэв.

– Минийх Панкратов. Байлдагч Халшинг ангидаа буцаж очихыг таны нүүрэн дээр тушаасныг бичгээр нотолж өгөхийг хүсье.

– Ёсоор болгоно! гэж дэслэгч ёслоод, – Явъя, байлдагч аа! гэв.

– Үүрд баяртай, нөхөр хошууч хэмээн Николай хоолой нь чичрэн өгүүлэв.

– Үүрд баяртай, чамд их баярлаж яваа шүү. Одоо явцгаа!

Саша ухаад л байв. Тэр газрыг модны бүдүүн төмөр утас шиг бөх хатуу үндэс барьчихсан, хүрз даахгүй заримыг нь сүхээр цавчихаас өөр аргагүй байв. Нэвт хөлөрсөн өмд, цамц нь биенд наалдан, хөл нь халуун оргино. Саша гутлаа тайлж модны хавьд тавив. Тэнд түүний автомат, гурван гранат, гар буу, хавчигтай ус энэ тэр байна.

Дахиад ухлаа. Тэнгэрт бөөн бөөн цагаан үүлс хөвсийж, тэртээ хаяанд түймэр улалзан, их бууны дуу нэг намдан, нэг нүргэлэн байна.

Саша бүсэлхийгээ хүртэл ухаад, нүхнээсээ гарч хөвөөг нь сайхан цэвэрлээд, Варяг хөнжил дээрээ чирж ойртуулснаа, доошоо дэвхрэн бууж, шарилыг хоёр гардан өргөөд булшны ёроолд тавив. Давчуухан байсан ч аяыг нь олж эвгэйхэн байрлуулж шинелиэр хучаад, малгайгаар нь бүтээх учир нүүрийг нь ил орхизнон, Варягийн уруул дээр энэ насандаа анх удаа үнсэв. Энэ нь бас сүүлчийнх.

Тэгээд дээшээ гарлаа. Энүүхэнд буун дуу, хөлийн чимээ гарч, германаар ярих, зүхэх, командлах сонсдож байна.

Саша гранат, гар буугаа зэхээд, унасан модон дээр автоматаа тавьж, ард нь отон хэвтэж авлаа. Бутсын дундуур хар ногоон цэрэг хувцас зуралзан, германууд юмыг яаж мэдэх вэ гэсэн шиг хий буудан, эгнээгээр урагшилцгааж явна. Тэгээд яг өмнөхөн нь гурван цэрэг ирмэгц Саша автоматаараа шүршиж, цаадуул нь ч уналаа. Дээрээс нь гранатаа шидээд өөрөө бөхийх зуур панхийн дэлбэрлээ, одоо ч эд нар босохгүй ээ!

Тэгтэл ч хэдэн талаас нь автомат тачигнаад явчихлаа. Одоо хэр цэрэг харагдахгүй, хэвтээд буудацгааж байгаа бололтой, сум нь унамал модыг ороолгох мэт чад чудхийн тусч байна.

Саша хүлээзнэв. Тэд нар босч, урагшаа дайрахгүй хаачих вэ дээ?! Санасан ёсоор боллоо. Баруун гар талд бут сэрвэлзэн, ногоон хувцас зуралзан үзэгдээд алга болсноо дахиад зуралзлаа. Саша тийш нь автомараараа галлангуут араас нь нэг гранатаа шидээд, зүүн тийш эргэн харвал тэнд нь бас ногоон хувцас зуралзлаа, тэр зүгт эцсийн гранатаа шидчихээд хойноос нь шүрших санаатай автоматаа барьж авсан ч буудаж чадсангүй, мод мөргөн унах нь тэр. түүнийг араас нь автоматаар шүршин алжээ.

Улангасч улайрсан германууд үсрэн ил гарцгааж, үхсэн Сашаг дахин нэг шүршиж, булаагүй булш руу бас бөөн сум тавиад гүйлдэн одоцгоов...

Германы довголгоог долдугаар сарын 10-нд зогсоов. Тэд тав хоногийн туршид дөнгөж арван нэгэн километр урагшилжээ. Зөвлөлтийн цэрэг сөрөг дайралт эхэлж, тэр нь хоёр мянган километрийн өргөнтэй ерөнхий довголгоо болж өрнөлөө.

Оршуулгын багийнхан суусан нэг муу хуучин “ГАЗ-АА” Рудово орох зам дээр, ойн хавьд зогсож байна. Багийнхан хэдийн цуглаж, тэвшин дээр тамхиа татаад сууцгаачихсан, хоёрхон хүн л дутуу байгаа аж.

– Тэр муу хоёр гайг би мэдэж байна, нэг дашмаг олж бутан дотор нуугдчихаад гударч байгаа гэж ахлагч зүхэлдэв.

– Юун дашмаг байх вэ дээ?! гэж тэвшний буланд сууж байгаа хөгшин цэрэг зөрөв. – Манай нэг алагдсан генерал юм уу хурандаа дээр орчихоо биз. Эсвэл зүгээр байлдагч нараас хэн нэгнийг оршуулахаар шийдсэн ч байж мэднэ.

– Бид биш, дивизийн баг оршуулах ёстой. Бид бол бичиг баримт л цуглуулах үүрэгтэй. Танд заавар уншиж өгөө биз дээ? гэж ахлагч дүрэмдэв.

– Заавар бол заавар, хүн бол талийгч ч гэсэн хүн.

– Хөгшин төгцөг, чи юу бураад байна гэж ахлагч бухимдав. – Манайх давшиж байгаа! Давшиж байхад хоцрох ямар ч эрх бидэнд байхгүй. Чи ойлгож байна уу?

– Гүйцээд л очно шүү дээ.

Эд нарыг үг сөрөхөд хүргэсэн хоёр бол оршуулгын багийн бусад гишүүдийн адил жагсаалын цэрэг бус ахимаг хүмүүс, тэд модон дундуур бэдэрч яваад булаагүй булштай таарчихаж. Дотор нь офицер эмэгтэй, тэрүүхэнд нь байгаа унамал модны дэргэд бас алуулсан хошууч хэвтэж байж.

– Хараач гэм, хошуучийн гутлыг аь хэзээний мулзалчихаж.

– Үгүй ээ, тэнд тавьсан байна, өөрөө тайлж л дээ, тэгэхээр, булшийг ч өөрөө ухсан байх нь, тэр хүрзийг харахгүй юү...

Тэр хоёр үхсэн Сашаг ар нуруугаараа эргүүлж, цэрэг цамцных нь халааснаас бичиг баримтыг нь авав.

– Хараач, хоёулангийнх нь бичиг баримт байна, тэгэхээр хошууч л хүүхнийг оршуулж байгаад амжаагүй байх нь. Алив, хоёулаа хүний ёсоор оршуулчихья.

– Хожигдчихно оо, нөгөө ахлагч чинь хуцаад эхэлнэ.

– Тэгж л байг, тэр муу!

Тэр хоёр Сашаг Варягийн хажууд байрлуулж нүхийг дүүргэж булаад, овгор шороон дээр нь хоёр гадас хатгаж, малгайг нь өлгөж орхив.

– Гутлыг нь авья, хромон гутал хаяхад хайран юм.

– Ахлагчид өгөөд амыг нь таглачихья.

– Хаагуур тэнэж яваад ирэв? гэж ахлагч тэдэн рүү дайрав.

– Тэнд нэг хошууч алуулчихсан байна, май, энэ гутал нь. Бас нэг ахмад хүүхэн булшинд байна. Нүх ухчихсан, хажууд нь хүрз байгаа юм чинь гээд бид хоёр шороогоор булчихья гэж шийдээд.

– Тэвш рүү гарцгаа, бичиг баримтыг нь данс хөтлөгчид өгөөрэй. Явцгаая! гэж ахлагч тушаав.

Машин хөдөллөө.

Данс хөтлөгч бичиг баримтыг нээж үзээд, чанга дуугаар ингэж уншив:

- Панкратов Александр Павлович, 1911 онд төрсөн, Иванова Варвара Сергеевна, 1917 онд төрсөн.
- Энэ чинь хэдтэй гэсэн үг болж байна гэж зүүрмэглэж суусан хөгшин цэрэг асуув.
- Эрэгтэй нь гучин хоёртой, эмэгтэй нь хорин зургаатай болж таарах нь.
- Мөн ч залуухан байж дээ гэж хөгшин цэрэг өгүүлэв.

1991–1994